
МОРМОНЫ
НОМ

СУРГААЛ БА
ГЭРЭЭ

АГУУ ҮНЭТ
СУВД

МОРМОНЫ НОМ

ЕСУС ХРИСТИЙН БАС НЭГЭН ГЭРЭЭ

СУРГААЛ БА ГЭРЭЭ

ЕСУС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМЭЭС ХЭВЛЭВ

АГУУ ҮНЭТ СУВД

ЕСУС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМЭЭС ХЭВЛЭВ
АНУ, ЮТА, СОЛТ ЛЕЙК ХОТ

Есүс Христийн Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн Сүмээс Хэвлэв
АНУ, Юта, Солт Лейк Хот

© 2007 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно

Printed in the United States of America 11/2008

19932007

Translation of the Book of Mormon, Doctrine and
Covenants, and Pearl of Great Price
Mongolian

АГУУЛГА

Мормоны Ном

Сургаал ба Гэрээ

Агуу Үнэт Сувд

Судруудын Удирдамж

Удиртгал

Цагаан толгойн дарааллаарх сэдвүүдийн жагсаалт

Библийн Иосеф Смитийн Орчуулганаас авсан Цуглуулга

Сүмийн түүх, Он дараалал, газрын зургууд хийгээд

гэрэл зургууд

Библийн Газрын зураг болон гэрэл зургууд

СУДРУУДЫН УДИРДАМЖ ДАХЬ ТОВЧЛОЛУУД БОЛОН ТЭМДЭГЛЭЭНҮҮД

Хуучин Гэрээ		Шинэ Гэрээ		Мормоны Ном	
Эхл.	Эхлэл	Мат.	Матай	1 Ниф.	1 Нифай
Ег.	Египетээс гарсан нь	Марк	Марк	2 Ниф.	2 Нифай
Лев.	Левит	Лук	Лук	Иаков	Иаков
Тоол.	Тооллого	Иохан	Иохан	Инос	Инос
Дэд хууль	Дэд хууль	Үйлс	Үйлс	Жер.	Жером
Иош.	Иошуа	Ром	Ром	Жер.	Жером
Шүүгч.	Шүүгчид	1 Кор.	1 Коринт	Омнаи.	Омнаи
Рут	Рут	2 Кор.	2 Коринт	Мор. үгс	Мормоны үгс
1 Сам.	1 Самуел	2 Кор.	2 Коринт	Моз.	Мозая
2 Сам.	2 Самуел	Гал.	Галат	Алма	Алма
Хаад. дээд	Хаадын дээд	Ефес	Ефес	Хил.	Хиламан
Хаад. дэд	Хаадын дэд	Филип.	Филиппой	3 Ниф.	3 Нифай
Шаст. дээд	Шастирын дээд	Кол.	Колосай	4 Ниф.	4 Нифай
Шаст. дэд	Шастирын дэд	1 Тес.	1 Тесалоник	Морм.	Мормон
Езра	Езра	2 Тес.	2 Тесалоник	Ифер	Ифер
Нех.	Нехемиа	1 Тим.	1 Тимот	Моро.	Моронай
Ест.	Естер	2 Тим.	2 Тимот	Сургаал ба Гэрээ	
Иов	Иов	Тит	Тит	С ба Г	Сургаал ба Гэрээ
Дуул.	Дуулал	Филе.	Филемон	АТ—1	Албан
Сур. үгс	Сургаалт үгс	Евр.	Еврей		Тунхаг—1
Ном. үгс	Номлогчийн үгс	Иаков	Иаков	АТ—2	Албан
Сол. дуу.	Соломоны дуун	1 Петр	1 Петр		Тунхаг—2
Иса.	Исаиа	2 Петр	2 Петр	Агуу Үнэт Сувд	
Иерем.	Иеремиа	1 Иох.	1 Иохан	Мосе	Мосе
Иер. гаш.	Иеремиагийн гашуудал	2 Иох.	2 Иохан	Абр.	Абрахам
Езек.	Езекиел	3 Иох.	3 Иохан	ИС—Мат.	Иосеф Смит—Матай
Дан.	Даниел	Иуд.	Иуда	ИС—Т.	Иосеф Смит—Түүх
Хосеа	Хосеа	Илч.	Илчлэлт	ИТ.	Итгэлийн Тунхаг
Иоел	Иоел			ИСО	Иосеф Смитийн Орчуулга
Амос	Амос			СУ	Судруудын Удирдамж
Обад.	Обадиа				
Иона	Иона				
Мика	Мика				
Нахум	Нахум				
Хабак.	Хабаккук				
Зефан.	Зефаниа				
Хаг.	Хаггаи				
Зехар.	Зехариа				
Малах.	Малахи				

ЕВР Еврей хэлнээс орчуулсан хувилбар.

Ө. Х. Өвөрмөц хэллэгийн болон хэлзүйн хэцүү байгууламжийн тайлбар.

ЭСВЭЛ, БУЮУ Хуучирсан үг хэллэгүүдийн утгыг тодруулахын тулд хувилбар үгс ашигласныг заадаг.

МОРМОНЫ НОМ

ЕСҮС ХРИСТИЙН

БАС

НЭГЭН ГЭРЭЭ

Мормоны Ном

НИФАЙН ЯЛТСУУДААС
АВАГДАЖ МОРМОНЫ ГАРААР
ЯЛТСУУД ДЭЭР БИЧИГДСЭН
ШАСТИР ОРШВОЙ

Иймийн тул, энэ нь Нифайн хүмүүсийн, мөн түүнчлэн леменчүүдийн цэдгийн хураангуйлал юм—Израилын угсааны үлдэгдэл болох леменчүүдэд мөн түүнчлэн Иудей болон харийнханд бичигдсэн болой—Зарлигийн замаар, мөн түүнчлэн бошиглолын мөн илчлэлтийн суу билгээр бичигдсэн бөлгөө—Мөн тэдгээр нь устгагдахгүй байж болохын тулд бичигдэн, лацдагдаж, мөн Их Эзэний тул далд хадгалагдсан бөлгөө—Бурханы бэлэг болон хүчээр энэ нь орчуулагдахын тулд ирэх болно—Моронайн гараар лацдагдан, мөн зохих цагтаа харийнханаар дамжин улиран ирэхийн тул Их Эзэний тул далд хадгалагдсан буюу—Үүний орчуулга нь Бурханы бэлгээр болой.

Тэднийг тэнгэрт хүрэх цамхаг барьж байхад нь, Их Эзэн хүмүүсийн хэл яриаг будлиулсан тэр цагт тараагдсан тэдгээр, Жаредын хүмүүсийн цэдэг болох, Иферийн номноос түүнчлэн авагдсан хураангуйлал бөлгөө—мөн Их Эзэний гэрээнүүдийг тэд мэдэж болохын тул, тэд үүрд зайлуулагдахгүй байхын тул Их Эзэн тэдний өвөг дээдэст ямар агуу зүйлүүдийг хийж өгснийг Израилын угсааны үлдэгдэлд үзүүлэх тэрхүү; мөн түүнчлэн өөрийгөө бүх үндэстнүүдэд үзүүлэх тэр Есүс бол Христ, Мөнхийн Бурхан хэмээн Иудей болон харийнханд итгүүлж—Мөн эдүгээ, хэрэв буруу буй бөгөөс тэдгээр нь хүмүүний алдаа бөлгөө; иймийн тул, та нар Христийн шүүлтийн суудлын өмнө толбогүй байж болохын тулд, Бурханы зүйлүүдийг бүү буруушаа.

Бага Иосеф Смит
ялтсуудаас англи хэлний эх орчуулгыг хийв.
Анхны англи хувь нь
1830 онд АНУ-ын Нью-Йоркийн Палмирад хэвлэгджээ.

УДИРТГАЛ

Мормоны Ном бол Библийн судартай харьцуулахуйц ариун судрын боть юм. Энэ нь үүрдийн сургаалыг бүрнээр нь тээх бөгөөд Америкийн эртний оршин суугчидтай хийсэн Бурханы үйлүүдийн цэдэг бөлгөө.

Уг ном нь бошиглол болон илчлэлтийн суу билгийн дагуу эртний олон бошиглогчоор бичиглэгдсэн болой. Алтан ялтсууд дээр бичиглэгдсэн тэдний үгс, Мормон хэмээн нэрлэгдсэн бошиглогч-түүхчээр иш татагдан мөн хураангуйлагдсан билээ. Уг цэдэг нь хоёр агуу их соёл иргэншлийн шастирыг өгүүлэх бөлгөө. Нэг нь МЭӨ (Манай Эриний Өмнөх) 600 онд Иерусалимаас ирсэн бөгөөд хожим нь нифайчууд мөн леменчүүд гэгдэх хоёр үндэстэн болон хуваагджээ. Нөгөө нь үүнээс ихэд эрт Их Эзэн Бабелын цамхагт хэл яриаг будлиулсан тэр үед иржээ. Энэ хэсэг нь жаредчууд хэмээн түүхэнд тэмдэглэгджээ. Мянга мянган жилийн дараа, леменчүүдээс бусад нь бүгд устгагдсан бөгөөд тэдгээр нь Америкийн индианчуудын өвөг дээдсийн нэг хэсэг болой.

Мормоны Номонд товчоологдсон тэргүүн чухал үйл явдал нь Их Эзэн Есүс Христ амилалтынхаа дараахан нифайчуудын дунд өөрийн биеэр тохинуулсан явдал юм. Энэ нь авралын төлөвлөгөөг тоймлон, сайн мэдээний номлолуудыг илэрхийлэн, мөн энэ амьдралдаа амар амгаланг, ирэх амьдралд мөнх авралыг олохын тулд тэд юу хийх ёстойг хүмүүнд хэлж өгдөг.

Мормон бичиглэлүүдээ гүйцээсний дараа, өөрийн цөөн үгсийг нэмж, мөн ялтсуудыг Кумора гүвээнд нуусан хүү Моронайдаа, тэрээр шастирыг гардуулсан билээ. 1823 оны 9 дүгээр сарын 21-нд, чухам тэрхүү Моронай, гэгээрэн, амилуулагдсан нэгэн, бошиглогч Иосеф Смит дээр хүрэлцэн ирж, мөн эртний цэдгийн тухай, мөн энэ нь Англи хэлэнд орчуулагдах ёстойг зааварлан хэлжээ.

Бурханы бэлэг болон хүчээр тэдгээрийг орчуулсан Иосеф Смитэд зохих үедээ уг ялтсууд хүргэгджээ. Уг цэдэг нь Есүс Христ бол амьд Бурханы Хүү болохыг мөн түүнд ирж түүний сайн мэдээний хуулиудыг болон ёслолуудыг дагасан бүхэн, хэн боловч аврагдаж болохыг гэрчилсэн шинэ бөгөөд нэмэлт гэрчлэл болон эдүгээ олон хэл дээр хэвлэгдээд байна.

Энэ цэдгийн талаар Бошиглогч Иосеф Смит: «Би ах нарт хэлсэнчлэн Мормоны Ном бол энэ дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв нь, мөн манай шашны тулгуурын чулуу, түүнчлэн бусад ямар ч номноос илүүгээр, үүний зааврыг мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох болой» гэжээ.

Иосеф Смитээс гадна, бусад арван нэгд, Мормоны Номны

тэнгэрлэг чанар хийгээд үнэний онцгой гэрчүүд болгон алтан ялтсуудыг нүдээрээ харах боломжийг Их Эзэн олгосон болой. Тэдний бичиглэсэн гэрчлэлүүд үүнтэй хамт «Гурван гэрчийн гэрчлэл» мөн «Найман гэрчийн гэрчлэл» хэмээн хавсаргагдсан буй.

Бид хаа газрын бүх хүмүүнийг Мормоны Номыг уншиж, үүний агуулсан зарыг зүрх сэтгэлдээ тунгааж, мөн түүнчлэн Бурханаас, Мөнхийн Эцэгээс, Есүс Христийн нэрээр энэ ном үнэн эсэхийг асуухыг урьж байна. Үүнчлэн үйлдсэн мөн итгэлтэйгээр асуусан хэн боловч Ариун Сүнсний хүчээр үүний үнэн болоод бурханлиг чанарын гэрчлэлийг олох болно. (Моронай 10:3–5-ыг үз).

Ариун Сүнснээс энэ бурханлиг гэрчлэлийг олсон хэн боловч тэдгээр нь мөнхүү хүчээр Есүс Христ бол энэ дэлхийн Аврагч, эдгээр эцсийн өдрүүдэд Иосеф Смит бол түүний илчлэгч мөн бошиглогч гэдгийг, мөн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол Мессиагийн хоёр дахь ирэлтийн бэлтгэл болж, энэ газар дэлхий дээр нэгэнтээ дахин байгуулагдсан Их Эзэний хаант улс юм гэдгийг мэдэж авах болно.

ГУРВАН ГЭРЧИЙН ГЭРЧЛЭЛ

Энэ ажил очих бүх улс, үндэстэн, хэлтэн болон хүмүүс мэдтүгэй: Эцэг, Бурханы мөн бидний Их Эзэн Есүс Христийн ач ивээлийн учир, Нифайн хүмүүсийн, мөн түүнчлэн тэдний ах нар болох леменчүүдийн, мөн түүнчлэн өмнө нь яригдсан цамхгаас ирсэн тэр, Жаредын хүмүүсийн цэдэг болох энэ цэдгийг агуулсан уг ялтсуудыг бид харсан бөлгөө. Мөн бид түүнчлэн тэдгээр нь Бурханы бэлэг болон хүчээр орчуулагдсаныг мэднэ, учир нь түүний дуу хоолой бидэнд үүнийг тунхагласан бөлгөө; иймийн тул бид уг ажил үнэнийг лавтай мэднэ. Мөн түүнчлэн ялтсууд дээрх тэр сийлбэрүүдийг харсан хэмээн бид гэрчилж байна; мөн тэдгээр нь хүний биш, харин Бурханы хүчээр бидэнд үзүүлэгдсэн билээ. Мөн Бурханы тэнгэр элч тэнгэрээс доош бууж ирэн, мөн тэрээр авчирч мөн бидний нүдний өмнө тавьснаар, бид ялтсуудыг бас түүн дээрх сийлбэрүүдийг үзэж басхүү харсныг бид чанд үгсээр тунхаглаж; мөн бид үзсэнээ мөн эдгээр зүйлүүд үнэн гэдгийг бид гэрчилж байгаа нь Эцэг Бурханы, мөн Их Эзэн Есүс Христийн ач ивээлээр гэдгийг бид мэднэ. Мөн энэ нь бидний нүдэнд гайхамшигт болой. Гэсэн хэдий ч, Их Эзэний дуу хоолой бид үүнийг нотлон мэдүүлэх ёстой хэмээн бидэнд зарлигласан бөлгөө, иймийн тул, Бурханы зарлигуудад дуулгавартай байхын тулд, бид эдгээр зүйлүүдийг гэрчлэн мэдүүлж байна. Мөн хэрэв бид Христэд итгэлтэй аваас, бид өмсгөлөө бүх хүмүүний цуснаас ангижруулж, мөн Христийн шүүлтийн суудлын өмнө толбогүй байж, түүнчлэн тэнгэрт түүнтэй мөнхөд хамт орших болно гэдгийг бид мэднэ. Мөн нэг Бурхан болох Эцэг, мөн Хүү, мөн Ариун Сүнсний алдар бадартугай. Амен.

ОЛИВЕР КАУДЕРИ
ДАВИД ВИТМЕР
МАРТИН ХАРРИС

НАЙМАН ГЭРЧИЙН ГЭРЧЛЭЛ

Энэ ажил очих бүх улс, үндэстэн, хэлтэн болон хүмүүс мэдтүгэй: Энэ ажлын орчуулагч Бага Иосеф Смит нь яригдаж асан тэр ялтсуудыг бидэнд үзүүлэв, алт мэт үзэгдэх тэдгээрийг болой; мөн сайхь Смитийн орчуулсан хуудас болгоныг бид өөрсдийн гараар гардаж барьсан бөлгөө; мөн түүнчлэн бид тэдгээрийн дээрх сийлбэрүүдийг харав, энэ бүгд нь эртний зүйл, мөн уран хийцтэй гэдэг нь үзэгдсэн бөлгөө. Мөн сайхь Смит бидэнд үзүүлснийг бид чанд үгсээр нотлон мэдүүлж байна, учир нь, бид харж мөн өргөж үзсэн, мөн сайхь Смитэд бидний ярьсан эдгээр ялтсууд байгаа гэдгийг лавтай мэднэ. Мөн бид харсан тэдгээр зүйлүүдээ энэ дэлхийнхэнд гэрчлэхээр, дэлхийд өөрсдийн нэрийг үлдээе. Мөн бид худал хэлээгүй, Бурхан үүнийг гэрчлэг.

Кристиа Витмер	Хайрам Пейж
Жаков Витмер	Иосеф Смит, Ахмад
Петр Витмер, Бага	Хайрум Смит
Жон Витмер	Самуел Х.Смит

БОШИГЛОГЧ ИОСЕФ СМИТИЙН ГЭРЧЛЭЛ

Мормоны Ном хэрхэн ирсэн тухай бошиглогч Иосеф Смитийн өөрийнх нь үгс:

«Есдүгээр сарын хорин нэгний орой [1823]...Бүхнийг Чадагч Бурханд би залбиран мөн өөрийгөө залбирахад эзэмдүүлэн байв....

«Тийнхүү би Бурханыг дуудах зуур би өрөөнд маань тэрхүү өрөөг үд дундынхаас илүү гэрэлтэй мэт болтол үргэлжлэн нэмэгдэх нэгэн гэрэл үзэгдэхийг бибээр олж мэдэхэд, нэгэн хүмүүн бие тэр даруй миний орны дэргэд, агаарт тогтож байгаагаар үзэгдэв, учир нь түүний хөл шаланд хүрэхгүй байв.

«Тэрээр туйлын тансаг цав цагаан элбэг орхимжтой байв. Энэ нь миний урьд үзсэн газар дэлхийн бүхнээс үлэмж цагаан байсан бөлгөө; бас би газар дэлхийн нэгээхэн ч зүйл ийм үлэмжийн цагаан мөн туяаран харагдахаар болгогдож чадна гэдэгт итгэх нь үгүй. Түүний гар, мөн түүнчлэн бугуйнаас бяцхан дээгүүр шуу хүртлээ нүцгэн байв; түүнчлэн, үүний нэгэн адил, түүний хөл, мөн шагайнаасаа бяцхан дээгүүр шилбэ хүртлээ нүцгэн байлаа. Түүний тэргүүн мөн хүзүү нь түүнчлэн ил байв. Би ил цухуйж буй түүний цээжийг хараад тэрбээр энэ орхимжноос өөр хувцас өмсөөгүйг мэдэв.

«Зөвхөн түүний орхимж л үлэмжийн цагаан байсан төдийгүй, бас түүний бүхий л бие үгээр дүрслэхийн аргагүй туяаран, мөн түүний дүр төрх үнэхээр цахилгаан мэт байв. Өрөө үлэмж гэрэлтэй байсан хэдий ч тэр хүмүүний эргэн тойрон дахь шиг тийм их хурц байсангүй. Би түүнийг анх хармагцаа айв; гэвч тэрхүү айдас намайг хоромхон зуур орхин одлоо.

«Тэрээр намайг нэрээр минь дуудаад, мөн надад хандан тэр бол Бурханы дэргэдээс надад илгээгдсэн элч гэдгийг, бас түүний нэр Моронай гэдгийг; надад зориулсан хийх нэгэн ажил Бурханд бийг, мөн миний нэр бүх үндэстэн, ястан болон хэлтнүүдийн дунд сайнаар бас муугаар дурсагдана, өөрөөр хэлбэл бүх хүмүүний дунд сайн болон муу аль алинаар нь яригдах болно гэдгийг хэлэв.

«Тэрээр алтан ялтсууд дээр бичиглэгдсэн, энэхүү эх газрын эртний оршин суугчдын тухай, мөн тэд хаанаас үүсэл гаралтайн тухай эх сурвалжийн шастирыг агуулсан нэгэн ном хадгалагдсаныг хэлэв. Түүнчлэн Аврагчаар эртний оршин суугчдад хүргэгдсэн үүрдийн Сайн мэдээний бүрэн байдал үүнд агуулагдсаныг тэрээр хэлэв;

«Түүнчлэн, мөнгөн хүрээнд суулгагдсан хоёр чулуу — мөн эдгээр чулуунууд, цээжний хуягтай холбогдож Урим ба Туммим гэгчийг бүрдүүлсэн — ялтсуудтай хамт хадгалагдсан буй; мөн эртний болон хуучин цагт эдгээр чулуунуудыг эзэмшин мөн хэрэглэсэн нь *Үзмэрчид* гэгддэг байжээ; мөн Бурхан тэдгээрийг уг номыг орчуулах зорилгын тул бэлтгэсэн билээ гэдгийг буюу.

«Түүнчлэн, тэдгээр ялтсуудыг авах цаг хараахан бүрдээгүй байсан болохоор би зөвхөн үзүүлэхийг зарлигласнаас бусад нэг ч хүнд би үзүүлэх ёсгүйг тэрээр надад хэлэв; мөн нэгэн адил Урим Ба Туммимтай цээжний хуягийг ч бөлгөө; хэрэв би тэгвээс би устгагдах ёстой болой. Түүнийг надай уг ялтсуудын тухай ярилцаж байх зуур миний оюунд үзэгдэл нээгдэн би уг ялтсууд хаана хадгалагдсаныг, мөн би тэнд очихдоо уг газрыг дахин танихуйц маш илэрхий бас тодорхойгоор харж чадав.

«Энэ харилцааны дараа, өрөөн дэх гэрэл надад хандан ярьж асан түүний биеийн эргэн тойронд л хуралдахыг би харж, мөн энэ нь түүний дэргэдээс бусдаар, өрөө дахин харанхуй болтол үргэлжлэв, би даруй харвал, шууд тэнгэрт дээш одох суваг байсан мэт, мөн тэрээр үзэгдэхгүй болтлоо дээшлэн одов, мөн өрөө энэ тэнгэрлэг гэрэл үзэгдэхээс өмнө байсан янзаараа үлдсэн байв.

«Би болсон явдлын өвөрмөц байдлыг бодон хэвтэв, мөн энэ ер бусын элчээр надад хэлэгдсэн зүйлд үлэмж ихээр гайхашран байв; намайг ийнхүү бодлогошрон байх зуур, өрөө маань дахин гэрэлтэж эхлэхийг би гэнэтхэн ажиглав, мөн агшин зуур мэт, мөнөөх тэнгэрлэг элч дахин орны минь дэргэд байв.

«Тэрээр эхэлж, мөн дахин эхний айлчлалынхаа үед ярьсантайгаад адил зүйлүүдийг өчүүхэн ч өөрчлөлтгүйгээр дахин өгүүлэв, үүнийг үйлдээд, тэрээр өлсгөлөн, илд мэс мөн өвчин тахлаар ирэх агуу сүйрэл болох тэрхүү, газар дэлхий дээр ирж буй аймшигт шийтгэлүүдийн тухай надад мэдүүлэв; мөн эдгээр хатуу шийтгэлүүд энэ үед дэлхийд ирэх бөлгөө. Эдгээр зүйлүүдийг өгүүлээд, тэрээр дахин урьдын адил дээшлэн одов.

«Энэ үед, миний оюунд маш гүнзгий сэтгэгдэл төрснөөс нойр маань хулжин, мөн үзсэн болон сонссон түүндээ, гайхал бахдалдаа эзэмдүүлэн хэвтэж байв. Гэвч мөнөөх элч орны минь дэргэд байхыг би дахин хараад, мөн урьдын адил зүйлүүдийг надад тэрээр дахин давтан өгүүлэхийг сонсоод би хичнээн их гайхсан гээч; мөн надад сануулга болгон нэмж (эцгийн минь гэр бүлийн ядуу тарчиг амьдралын үр дагаврын улмаас) ялтсуудыг баяжих зорилгын тулд эзэмшүүлэхээр Сатан намайг уруу татахыг хичээх болно гэдгийг хэлэв. Үүнд тэрээр надад хориг тавин, бибээр уг ялтсуудыг авахдаа Бурханыг алдаршуулахаас өөр бусад ямар ч сонирхлоос татгалзах ёстой хэмээв, мөн Түүний хаант улсыг байгуулахаас өөр ямар нэгэн шалтгааны нөлөөнд автагдах ёсгүйг; эс бөгөөс би тэдгээрийг авч чадахгүйг хэлэв.

«Энэхүү гурав дахь айлчлалын дараа, тэрээр дахин урьдын адил тэнгэрт дээшлэн одов, мөн би дөнгөж тохиолдсон зүйлийн хачныг гайхан тунгаахаар дахин ганцаараа хоцорсон байв; тэгээд мөнөөх тэнгэрлэг элч намайг гурав дахь удаагаа орхин дээшилсний дараа бараг тэр даруй, азарган тахиа донгодов,

мөн би өдөр ойртож буйг, иймээс бидний уулзалт бүхэл шөнийг эзэлснийг мэдэв.

«Би үүний дараа удалгүй орноосоо босож, мөн ердийн байдлаараа өдрийн зайлшгүй хийх ажилдаа гарлаа; гэвч, ердийнхөөрөө ажиллахыг оролдох зуур, хүч минь шавхагдсанаас, ажиллах боломжгүй байгаагаар мэдэв. Надтай хамт ажиллаж байсан миний эцэг, миний жирийн бус байдлыг ажиглаад, мөн гэртээ харь гэж надад хэлэв. Би байшин уруугаа очих санаатай явж эхлэв; гэвч бидний байсан талбайгаас гарахаар хашааг давахаар оролдох үед, бүх хүч минь шавхагдан, би арчаагүйгээр газарт унаж, тэгээд хэсэг хугацаанд юуг ч мэдэхгүй ухаан алдсан байлаа.

«Миний юун түүрүүнд сэхээрч чадсан зүйл нь надад хандан ярьж, намайг нэрээр минь дуудах дуу байлаа. Би дээш харж, мөн мөнөөх элч миний толгойн тус тэр янзаараа гэрлээр хүрээлүүлэн зогсож байхыг үзэв. Тэгээд тэрээр урьд шөнө надад ярьсныгаа бүгдийг дахин ярьж, тэгээд эцэгтээ очиж бас түүнд өөрийн хүлээн авсан тэр үзэгдэл мөн зарлигуудын тухай хэлэхийг надад зарлиг болов.

«Би дагав; би талбайд аавдаа буцаж очоод, мөн бүхий л болсон явдлыг түүнд давтан хэлэв. Тэрээр энэ бол Бурханаас байсан хэмээн надад хариулж, мөн явж бас уг элчээр зарлиг болсныг хий гэж надад хэлэв. Би талбайг орхин, мөнхүү элч уг ялтсууд хадгалагдсаныг надад хэлсэн тэр газар уруу явлаа; мөн үүний талаар би үзэгдэлд тодорхой харсан учраас, би тэнд очсон даруйдаа уг газрыг танив.

«Нью-Йоркийн, Онторио гүнлэгийн Манчестер тосгоны ойролцоо, орчин тойрондоо хамгийн өндөр болох нилээд томоохон гүвээ байдаг. Энэ гүвээний баруун талд, оргилоос нь холгүй, томоохон чулууны дор, чулуун хайрцганд хадгалагдсан ялтсууд буй. Энэ чулуу нь төв рүүгээ дээш товойсон зузаан, харин захаараа нимгэвтэр учир төв хэсэг нь газраас дээш харагдахаар, харин эргэн тойрон бүх захын хэсэг нь шороонд булагдсан байлаа.

«Шороог нь зайлуулаад, би хөшүүрэг олж аван, үүнийг би чулууны зах доогуур ивж, мөн бага зэрэг хүчлээд үүнийг дээш өргөв. Би дотогш харж, мөн элчийн дурдсан уг ялтсуудыг, басхүү Урим ба Туммим, мөн цээжний хуягийг үнэхээр үзэв. Тэдгээр зүйлс дотор нь байсан уг хайрцгийг, чулуунуудыг нэгтгэн ямар нэгэн зуурмагаар бүрсэн байлаа. Уг хайрцагны ёроолд хоёр чулууг хэрээс болгон хөндөлдүүлэн тавьж, мөн эдгээр чулуунууд дээр ялтсууд болон тэдэнтэй хамт бусад зүйлүүд тавигдсан байв.

«Би тэдгээрийг гаргахаар завдсан боловч, элчээр хориглогдсон, мөн тэдгээрийг авчрах цаг нь харахан болоогүй, тэр цагаас дөрвөн жилийг улиртал энэ нь тохиохгүй гэснийг дахин сана; гэвч тэрээр би тэр цагаас яг нэг жилийн дараа уг газарт ирвэл зохино гэдгийг, мөн тэрээр тэнд надтай уулзана гэдгийг,

түүнчлэн уг ялтсуудыг авах цагийг иртэл би тэрчлэн үйлдэх ёстойг надад хэлсэн бөлгөө.

«Тэрчлэн надад зарлигласны дагуу, би жил бүрийн эцэст очиж, мөн тухай бүрд би мөнөөх элчтэй тэнд уулзаж, тэгээд Их Эзэн юу хийх гэж буй тухай, мөн Түүний хаант улс хэрхэн бас ямархуу маягаар эцсийн өдрүүдэд удирдагдахыг заавар ба мэдлэг болгон бидний ярилцлага бүрд түүнээс хүлээн авч байлаа.

* * * * *

«Эцэст нь уг ялтсуудыг, Урим ба Туммимыг мөн цээжний хуягийг авах цаг боллоо. Нэг мянга найман зуун хорин долоон оны есдүгээр сарын хорин хоёрны өдөр ердийн адил тэдгээр нь хадгалагдсан байгаа газарт жилийн эцсээр ирэхэд, урьд уулзсан тэнгэрлэг элч доорх үүргийг хүлээлгэхийн хамт тэдгээрийг надад гардуулав; би тэдгээрийн төлөө хариуцлага хүлээх ёстой болов; хэрэв би тэдгээрийг хайнгаас, эсвэл өөрийн хайхрамжгүйгээс алдвал, би тусгаарлагдах ёстой болно; гэвч хэрэв би өөрийн бүхий л хүчээр тэдгээрийг хадгалахыг чармайх аваас тэр, уг элч, тэдгээрийг хүсэх хүртэл, тэдгээр нь хамгаалагдах болно.

«Яагаад тэдгээрийг аюулгүй байдалд хадгалах тийм хатуу чанд үүрэг хүлээн авсан, мөн юуны учир миний гарт даалгагдсаныг хийж гүйцэтгэсний дараа, тэрээр тэдгээрийг хүсэх болно хэмээн уг элчийн хэлсэн шалтгааныг би удалгүй олж мэдсэн бөлгөө. Тэдгээрийг надад байгаа гэдэг нь мэдэгдмэгц тэдгээрийг надаас авахын тул хамгийн идэвхтэй оролдлогууд хэрэглэгдэж байлаа. Уг зорилгын төлөө хүний санаанд орж болох бүхий л заль мэх сэдэгдэн хэрэглэгдэж байв. Хавчлага урьдынхаасаа улам хэрцгий бас хэцүү бэрх болж, мөн бүлэг хүмүүс хэрэв боломж олдвол тэдгээрийг надаас авахаар үргэлжийн сонор байлаа. Гэвч Бурханы мэргэн ухаанаар, тэдгээр нь миний гарт аюулгүй байдалд, гарт минь даалгасан тэдгээрийг биелүүлтэл үлдсэн бөлгөө. Тохиролцсоны дагуу, уг элч тэдгээрийг хүсэхэд би түүнд тэдгээрийг өргөн барьсан билээ; мөн тэрээр тэдгээрийг өөрийн мэдэлд энэ өдөр болох нэг мянга найман зуун гучин найман оны тавдугаар сарын хоёр дахь өдрийг хүртэл байлгаж буй болой.»

Бүрэн цэдгийг, Агуу Үнэт Сувдад буй Иосеф Смит — Түүх мөн *History of The Church of Jesus Christ of Latter-day Saints* (Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Түүхийн) нэгдүгээр боть, нэгээс зургадугаар бүлгийг үз.

Булшнаас яригч хүмүүний дуу хоолой болж газраас авчрагдсан тэрхүү эртний цэдэг, Тэнгэрлэг нотолгоогоор гэрчлэх адил Бурханы бэлэг болон хүчээр одоогийн хэлэнд орчуулагдаж, мөнхүү *The Book of Mormon* хэмээгдэн 1830 онд англи хэлээр энэ дэлхийд анх хэвлэгдсэн бөлгөө.

МОРМОНЫ НОМЫН

ТУХАЙ ТОВЧ ТАЙЛБАР

Мормоны Ном бол төмөрлөг ялтсууд дээр сийлэгдсэн, эртний Америк дахь хүмүүсийн ариун нандин цэдэг билээ. Уг номонд дөрвөн янзын төмөрлөг ялтсууд дурдагдсан нь:

1. Хоёр төрөл байсан *Нифайн ялтсууд*: Бага ялтсууд мөн Их ялтсууд буй. Эхнийх нь сүнслэг хэрэг явдлууд мөн бошиглогчдын тохинуулал болон сургамжуудад илүү онцгойлон зориулагдсан буюу, харин сүүлийнх нь ихэвчлэн хүмүүсийн тухай төрийн түүхийг агуулах бөлгөө (1 Нифай 9: 2–4). Хэдий тийм ч, Мозаягийн цагаас, Их ялтсууд нь түүнчлэн сүнслэг чухал ач холбогдолтой зарим зүйлүүдийг багтаасан ажгуу.
2. Нифайн Их ялтсуудаас олон тайлбартайгаар Мормоноор хураангуйлагдан бүрдсэн *Мормоны ялтсууд*. Эдгээр ялтсууд нь түүнчлэн Мормоноор хийгдсэн мөн түүний хүү Моронайгаар нэмэлт нь хийгдсэн түүхийн үргэлжлэлийг агуулах бөлгөө.
3. Жаредчуудын түүхийг толилуулсан *Иферийн ялтсууд*. Энэ цэдэг нь «Иферийн Ном» гэсэн нэрийн дор ерөнхий түүхийн хамт өөрийн санааг хавсарган нэгтгэсэн тэрхүү Моронайгаар хураангуйлагдсан билээ.
4. МЭӨ 600 онд Иерусалимаас Лихайн хүмүүсээр авчрагдсан *Гуулин ялтсууд*. «Эдгээр нь: Мосегийн таван ном,... мөн түүнчлэн иудейчүүдийн цэдгийг эхлэлээс нь,... Иудейн хаан Зедикаягийн хаанчлалын эхлэлийг хүртэл; мөн түүнчлэн ариун бошиглогчдын бошиглоуудыг »агуулах бөлгөө (1 Нифай 5:11–13). Библи дэх Исаиагаас болон Библийн сударт дурдагдаагүй бусад бошиглогчдоос иш татагдсан эдгээр ялтсуудын олон ишлэл Мормоны Номонд орсон билээ.

Мормоны Ном нь тус бүрдээ ерөнхий бичиглэгчийнхээ нэрээр онцгойлогдон, нэгээс бусад нь номуудын адил нэрлэгдсэн, арван таван үндсэн хэсэг буюу бүлгүүдээс бүрдэх бөлгөө. Эхний хэсэг нь (Омнайгаар төгсгөл болох эхний зургаан ном), Нифайн Бага ялтсуудын орчуулга юм. Омнаин болон Мозаягийн номнуудын хоорондох нь Мормоны Үгс гэж нэрлэгдсэн хавсралт болно. Энэ хавсралт Бага ялтсууд дээр сийлэгдсэн цэдгийг Их ялтсуудаас Мормоны хийсэн хураангуйлалтай холбодог.

Хамгийн урт хэсэг болох Мозаягаас Мормоны долдугаар бүлэг хүртэл багтаасан нь Нифайн Их ялтсуудаас хийсэн

Мормоны хураангуйллын орчуулга юм. Сүүлчийн хэсэг нь Мормоны наймдугаар бүлгээс уг ботийг төгсгөн, эцгийнхээ амьдралын цэдгийг төгсгөсний дараа, жаредчуудын цэдгийн (Иферийн Ном) хураангуйллыг хийж хожим нь Моронайн Ном хэмээн нэрлэгдсэн хэсгүүдийг нэмсэн Мормоны хүү Моронайгаар сийлбэрлэгдсэн болой.

МЭ 421 оны үед, нифайчуудын эцсийн бошиглогч-түүхч, Моронай уг ариун нандин цэдгийг битүүмжлэн, Бурханы дуу хоолойгоор түүний эртний бошиглогчдын дунд угтан хэлэгдсэний дагуу, хожмын өдрүүдэд авчрагдахын тулд Их Эзэний төлөө далдалсан буюу. МЭ 1823 онд мөнөөх Моронай, амилуулагдсан хүмүүн бие, Бошиглогч Иосеф Смитэд айлчилж мөн дараа нь түүнд сийлбэрлэгдсэн ялтсуудыг хүргэсэн билээ.

МОРМОНЫ НОМОН

ДАХЬ НОМУУДЫН ДЭС ДАРААЛАЛ БА НЭРС

<i>Нэрс</i>	<i>Хуудас</i>
Нифайн Нэгдүгээр Ном	1
Нифайн Хоёрдугаар Ном	73
Иаковын Ном	163
Иносын Ном	189
Жеромын Ном	192
Омнаин Ном	195
Мормоны Үгс	199
Мозаягийн Ном	201
Алмагийн Ном	287
Хиламаны Ном	516
Гуравдугаар Нифай	571
Дөрөвдүгээр Нифай	650
Мормоны Ном	655
Иферийн Ном	681
Моронайн Ном	726

НИФАЙН НЭГДҮГТЭЭР НОМ

ТҮҮНИЙ ХААНЧЛАЛ БА ТОХИНУУЛАЛ

Лихай болон түүний эхнэр Сариа, мөн түүний (ахмадаас дэслэн) Лемен, Лемүел, Сам болон Нифай хэмээн нэрлэгдэх дөрвөн хөвгүүний шастир оршвой. Лихай хүмүүст тэдний ёсон бус үйлийн тухай бошиггосноос тэд түүний амийг бүрэлгэхээр эрэлхийлэн буй тул Иерусалимаас одохыг Их Эзэн түүнд сэргийлэн сануулжээ. Тэр гэр бүлийнхээ хамт гурав хоногийн турш аглаг буйдад зорчив. Нифай ах нараа аваад иудейчүүдийн цэдгийн төлөө Иерусалимын зүг буцсан болой. Тэдний зүдгүүрүүдийн шастир оршвой. Тэд Ишмэил гэгчийн охидыг эхнэр болгон авав. Тэд гэр бүлээ авч аглаг буйд тийш одов. Аглаг буйд дахь тэдний зовлон ба зүдгүүр. Тэдний аялсан замнал. Тэд их усанд ирэв. Нифайн ах нар түүнийг эсэргүүцэв. Тэрээр тэднийг шившиглэж, мөн усан онгоц босгов. Тэд уг нутгийг Өгөөмөр хэмээн нэрийдэв. Тэд их усыг гатлан амлагдсан нутагт хүрэв гэхчилэнгээр өгүүлэх ажгуу. Энэ нь Нифайн шастирын дагуу; эсвээс өөрөөр хэлбэл, би, Нифай, энэхүү цэдгийг бичиглэв.

БҮЛЭГ 1

Нифай өөрийн хүмүүсийн цэдгийг бичиглэж эхлэв—Лихай үзэгдлээр галан баганыг харж мөн бошиггослын номноос уншив—Тэрээр Бурханыг шагшин, Мессиаг ирэхийг зөгнөн, мөн Иерусалимын устгалыг бошиглов—Тэрбээр иудейчүүдээр хавчигдав. Ойролцоогоор мээ 600 он.

БИ,^аНифай, ^ббуянт сайн учир, тиймийн тул миний бие эцгийнхээ бүхий л эрдэм мэдлэгт зарим талаар ^ссургагдсан

байв; бас амьдралынхаа турш өчнөөн ^дзүдгүүрийг туулсан хэдий ч, амьдралынхаа бүхий л өдрүүдэд би Их Эзэний өндөр их ээл хишгийг хүртэж, тийм ээ, Бурханы ^енууц болон сайн сайхны агуу их мэдлэгийг олсны учир, тийнхүү би өөрийн өдрүүдэд үзэж үйлдсэнээ ^жцэдэглэх бөлгөө.

2 Тийм ээ, би иудейчүүдийн эрдмээс мөн египетчүүдийн хэлнээс боловсорсон эцгийнхээ ^з“хэлэн дээр цэдгийг товчоолох ажгуу.

3 Мөн миний үйлдэх тэрхүү цэдэг ^г“үнэн гэдгийг би мэднэ;

[1 НИФАЙ]

1 ^а1а су Нифай, Лихайн хүү.
^бСур. үгс 22:1.
^вС ба Г 68:25, 28.
су Эцэг эх.

^гИнос 1:1;
Мозая 1:2–3.
су Заах, Багш.
^дсу Дайсан.
^есу Бурханы нууцууд.
^жсу Судрууд.

2а Мозая 1:2–4;
Морм. 9:32–33.
3а 1 Ниф. 14:30;
Мозая 1:6;
Ифер 5:1–3;
С ба Г 17:6.

басхүү би үүнийг өөрийн гараар үйлдэв; басхүү би үүнийг өөрийн мэдлэгээр бүтээх бөлгөө.

4 Учир нь улиран тохиох дор Иудейн хаан “Зедикая засаглан суух ^банхны жилийн эхэнд (миний эцэг, Лихай, амьдралынхаа бүх өдрүүдэд “Иерусалимд суурьшин байсан ажгуу); мөн чухамхүү тэр л онд олон бошиглогч хүмүүст хандан тэднийг нүглээ наманчлах ёстой, эс бөгөөс их хот ‘Иерусалим устгагдах ёстойг ^вбошиглож байсан ажгуу.

5 Иймийн тул улиран тохиох дор миний эцэг, “Лихай, тэрээр урагш одох зуураа Их Эзэнд залбирав, тийм ээ, тэр ч байтугай бүх ^сэртгэл зүрхээрээ түмэн олныхоо төлөө залбирав.

6 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Их Эзэнд хандан залбирах үед, галан “багана тодорч мөн түүний өмнө хэвтэх чулуун дээр тогтон үзэгдэв; мөн тэрээр ихийг үзэж бас сонсов; басхүү тэрбээр өөрийн үзэж, сонссон зүйлүүдийн улмаас үлэмж ихээр чичрэн дагжив.

7 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Иерусалим дахь

гэртээ буцав; чингээд Сүнс ба өөрийн үзсэн зүйлүүдийн улмаас “догдлон байсны учир тэрээр биеэ ор дэвсгэртээ хадан байсан ажээ.

8 Мөн ийнхүү Сүнснээс болж сульдсаны учир, тэрбээр өөрийн биеэс халин “үзэгдэлд зорчихуй дор, тэрээр ^бтэнгэр нээгдэхийг үзсэн буюу, тэрээр өөрийн тунгааснаар асар тэнгэрт Бурханыг магтан дуулах тоо томшгүй олон тэнгэр элчээр хүрээлүүлэн Бурхан хаан сэнтийдээ залран буйг харжээ.

9 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Нэгэн бие асар тэнгэрээс доошлон буухыг, басхүү тэрээр түүний “туяаран гэрэлтэх нь үдийн нарнаас ч хурц болохыг харсан ажээ.

10 Мөнхүү тэрбээр түүнчлэн түүнийг шадарлан буй өөр бусад “арванхоёрыг харав, басхүү тэдний гэрэлтэх нь огторгуй дахь одноос ч үлэмж давуутай бөлгөө.

11 Мөн тэд доошлон ирж басхүү урагшлан дэлхийн гадаргуугаар одов, мөн тэргүүлэн буй нь ирж, басхүү эцгийн минь өмнө зогсоод, мөн нэгэн “номыг түүнд өгөөд, түүнчлэн тэрбээр уг

4а Шаст. дэд 36:10;
Иер. 52:3–5;
Омнаи 1:15.
б су Он дараалал—
598 мээ.
в Шаст. дээд 9:3.
г Хаад. дэд 17:13–15;
Шаст. дэд 36:15–16;
Иер. 7:25–26.
су Бошиглогч.
д Иер. 26:18; 2 Ниф. 1:4;

Хил. 8:20.
5а су Лихай, Нифайн
эцэг.
б Иаков 5:16.
6а Ег. 13:21;
Хил. 5:24, 43;
С ба Г 29:12;
ИС—Т 1:16.
7а Дан. 10:8;
1 Ниф. 17:47;
Моце 1:9–10;

ИС—Т 1:20.
8а 1 Ниф. 5:4.
су Үзэгдэл.
б Езек. 1:1;
Үйлс 7:55–56;
1 Ниф. 11:14;
Хил. 5:45–49;
С ба Г 137:1.
9а ИС—Т 1:16–17.
10а су Төлөөлөгч.
11а Езек. 2:9.

номыг уншвал зохилтой хэмээн тушаажээ.

12 Мөнхүү улиран тохиох дор тэрээр уншихад, тэрбээр Их Эзэний “Сүнсээр дүүргэгдсэн ажгуу.

13 Мөнхүү тэрээр уншаад өгүүлрүүн: Ай халаг, ай халаг Иерусалим минь, би чиний “жигшүүрт үйлүүдийг харан байна! Тийм ээ, мөн миний эцэг “Иерусалимын тухай олон зүйлийг уншсан—энэ нь, бас тэндхийн оршин суугчид устгагдахыг; олон нь илдэнд эрсдэж, мөн олон нь олзлогдож Вавилонд “хүргэгдэхийг болой.

14 Мөнхүү улиран тохиох дор миний эцэг олон агуу хийгээд гайхамшигт зүйлүүдийг харж бас уншаад, тэрээр уулга алдаж Их Эзэнд хандан: Таны үйлдэхүй дор ямар агуу хийгээд гайхамшигтай вэ, Ай Их Эзэн, Бүхнийг Чадагч Бурхан минь! Таны сэнтий өндөр тэнгэрт буй, мөн таны хүчин, басхүү сайн сайхан, мөн нигүүлсэл тань газар дэлхийн оршин амьдрагч бүхний дээр буй; мөн та нигүүлсэнгүй учир, танд “ирэх тэдний мөхөхийг та үл тэвчих буйза! гэх мэт олон зүйлийг өгүүлэв.

15 Мөн эцгийн минь Бурханаа магтан дуулах хэл иймэрхүү байлаа; учир нь түүний

бодгаль баясан басхүү бүх сэтгэл зүрх нь дүүргэгдэв; түүний үзсэн зүйл, тийм ээ, Их Эзэн түүнд үзүүлсэн зүйлүүдийн улмаас бөлгөө.

16 Мөн эдүгээ би, Нифай, эцгийнхээ бичсэн зүйлүүдийн бүрэн шастирыг үйлдэхгүй, учир нь тэрээр өөрийн харсан үзэгдлүүд хийгээд зүүднээс олон зүйлийг бичиглэсэн, басхүү тэрбээр хүүхдүүддээ “бошиглон мөн ярьсан олон зүйлийг бичиглэснийг нь би нэг бүрчлэн сийрүүлэн үйлдэхгүй буюу.

17 Харин би өөрийн өдрүүдэд үйлдсэнийхээ шастирыг үйлдэх болой. Болгоогтун, би эцгийнхээ “цэдгийг “хураангуйлан, би өөрийн гараар бүтээсэн ялтсууд дээрээ буулгав; иймийн тул бибээр эцгийнхээ цэдгийг хураангуйлсны төгсгөлд би амьдралынхаа шастирыг үйлдэх бөлгөө.

18 Тиймийн тул, Их Эзэн үлэмж олон ер бусын гайхамшигт зүйлүүдийг миний эцэг, Лихайд үзүүлсний дараа, тийм ээ, Иерусалимын “устгалын тухай, болгоогтун, тэрбээр хүмүүсийн дунд орж, мөн өөрийн сонссон болон үзсэн зүйлүүдийн талаар тэдэнд “бошиглон тунхаглаж эхэлснийг та бүгд мэдээсэй хэмээнэ би.

12a С ба Г 6:15.

13a Хаад, дэд 24:18–20;

Шаст. дэд 36:14.

б Хаад, дэд 23:27; 24:2;

Иер. 13:13–14;

2 Ниф. 1:4.

в Хаад, дэд 20:17–18;

2 Ниф. 25:10;

Омнаи 1:15.

14a Алма 5:33–36;

3 Ниф. 9:14.

16a 1 Ниф. 7:1.

17a 1 Ниф. 6:1–3; 19:1–6;

2 Ниф. 5:29–33;

С ба Г 10:38–46.

б 1 Ниф. 9:2–5.

18a 2 Ниф. 25:9–10;

С ба Г 5:20.

б су Бошиглох,

Бошиглал.

19 Мөнхүү улиран тохиох дор тэдний талаар түүний гэрчлэн мэдүүлсэн зүйлүүдийн учир иудейчүүд түүнийг “доромжлон элэглэв; учир нь тэрээр тэдний жигшүүрт хэргүүд болон тэдний ёс бусын үйлийг үнэнээр гэрчилж, мөн сонссон басхүү үзсэн зүйлүүд хийгээд түүнчлэн номноос уншсан зүйлүүд, ⁶Мессиагийн ирэх хийгээд түүнчлэн дэлхийн гэтэлгэлийг илэрхийгээр мэдүүлсэн гэдгийг тэрбээр гэрчилсэн болой.

20 Мөн иудейчүүд эдгээр зүйлийг дуулаад түүнд уурлан; тийм ээ, түүгээр үл барам тэднийг “хөөн зайлуулж, чулуугаар шидэн хороосон, хөнөөж егүүтгэсэн тэрхүү эрт цагийн бошиглогчдын адилаар, бас тэд түүний амийг тэрчлэн үзэж, тэд амийг нь авахаар эрэлхийлсэн ажгуу. Гэвч болгоогтун, итгэлийнх нь учир бүр тэднийг аюулаас ангижрах чадалтай болтол нь хүчтэй болгохоор сонгосон бүгдийн дээр Их Эзэний ⁶нигүүлсэл байдгийг би, Нифай та нарт үзүүлэх болно.

БҮЛЭГ 2

Лихай гэр бүлээ Улаан тэнги-

сийн дэргэдэх аглаг буйд тийш авчрав—Тэд хөрөнгө хогшлоо орхив—Лихай Их Эзэнд тахил өргөн мөн зарлигуудыг дагахыг хөвгүүддээ сургамжлав—Лемен Лемүел хоёр эцгийнхээ эсрэг бүвтналдав—Нифай дуулгавартай байж басхүү итгэлтэйгээр залбирав; Их Эзэн түүнд ярьж, мөн тэр ах нараа удирдахаар сонгогдов. Ойролцоогоор мээ 600 он.

Учир нь болгоогтун, улиран тохиох дор Их Эзэн эцэгт минь хэлэв, тийм ээ, бүр зүүд нойронд нь түүнд өгүүлсэн нь: Үйлдсэн зүйлүүдийнхээ учир Лихай чи адислагдсан нэгэн болой; бас итгэлтэй байж мөн миний чамд зарлигласан зүйлүүдийг чи энэ хүмүүст тунхагласны учир, болгоогтун, тэд амийг чинь “авахаар эрэлхийлэх авай.

2 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн миний эцэгт, бүр “зүүд нойронд нь, тэрээр гэр бүлээ ⁶авч мөн аглаг буйд тийш одвол зохино хэмээн “зарлиглажээ.

3 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Их Эзэний үгийг “дуулгавартай дагасан буюу, иймийн тул тэр Их Эзэн өөрт нь зарлигласнаар үйлдсэн ажгуу.

4 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр аглаг буйд тийш одов. Мөн тэр өөрийн гэр, бас

19a Шаст. дэд 36:15–16;
Иер. 25:4;

1 Ниф. 2:13; 7:14.

б су Мессиа.

20a Хил. 13:24–26.

б Алма 34:38;

С ба Г 46:15.

су Нигүүлсэнгүй,
Нигүүлсэл.

2 1a 1 Ниф. 7:14.

2a су Зүүд.

б Эхл. 12:1;

2 Ниф. 10:20;

Ифер 1:42; Абр. 2:3.

в 1 Ниф. 5:8; 17:44.

3a су Дуулгавартай
байх, Дуулгавартай,
Дуулгавартай
дагах.

өвлөж ирсэн нутгаа, бас алт болон мөнгөө, бас үнэт зүйлсээ орхин, мөн гэр бүлийн хамт хоол хүнс, бас майхнаас өөр юуг ч эс аван аглаг буйдыг “зорин одсон ажгуу.

5 Мөнхүү тэрээр Улаан тэнгисийн хөвөөнд ойр орших хязгаар нутагт уруудан ирэв; бас тэрээр “Улаан тэнгисийн ойр орших хил хязгаарыг дагаж аглаг буйдад аялсан авай; басхүү тэрээр миний эх Сариа болон миний ах нар ⁶Лемен, Лемүел мөн Самаас бүрдсэн гэр бүлтэйгээ аглаг буйдад аялсан ажгуу.

6 Мөнхүү улиран тохиох дор тэрээр гурав хоног аглаг буйдад аялаад, тэрбээр нэгэн “хөндийд, уст голын дэргэд майхнаа босгов.

7 Мөнхүү улиран тохиох дор тэрээр “тахилын ⁶чулуун ширээ босгон, Их Эзэнд өргөл үйлдэн, бас Их Эзэн Бурхандаа “талархлаа мэдүүлсэн авай.

8 Мөнхүү улиран тохиох дор тэрээр эл голыг Лемен хэмээн нэрийдэв, мөн тэр нь Улаан тэнгист цутгадаг байв; мөн уг хөндий нь голын цутгалад ойрхон байсан болой.

9 Мөн эцэг минь тэр голын ус Улаан тэнгисийн усны сан уруу шавхагдан юүлэгдэхийг хараад, тэрээр Леменд

хандаж, өгүүлрүүн: Ай чи энэ гол мэт бүхий л зөв шударгын сан уруу зогсолтгүй тэмүүлэх болоосой хэмээв!

10 Мөн түүнчлэн тэрбээр Лемүелд хандан, Ай Их Эзэний зарлигуудыг дагахдаа чи энэ хөндий мэт тууштай бас гуйвшгүй бас хөдөлшгүй байгаасай хэмээв!

11 Эдүгээ тэрээр эдгээрийг Лемен Лемүел хоёрын зөрүүд араншингийн учир өгүүлсэн ажгуу; учрыг болгоогтун “эцэг нь ⁶зөнч байж, мөн өвлөгдөж ирсэн газраа, мөн алт болон мөнгөө, бас үнэт зүйлсээ орхин, тэднийг Иерусалим нутгаас гадагш дагуулан, аглаг буйдад амь өрсөх болгосон тул тэд эцгийн хэлсэн олон зүйлийг эсэргүүцэн “бувтналдав. Мөн түүнийг зүрх сэтгэлийнхээ хоосон төсөөллийн улмаас ийнхүү үйлдэв хэмээн тэд хэлэлцжээ.

12 Мөн ийнхүү, хөвгүүдийн ахмад нь болох Лемен, Лемүел хоёр эцгийнхээ эсрэг бувтналдсан ажээ. Мөн, тэд өөрсдийг нь бүтээсэн Бурханы үйлсийг “мэдээгүйн улмаас бувтналдсан болой.

13 Тэд бас их хот Иерусалим, бошиглогчдын хэлсэнчлэн “устгагдаж болно гэдэгт итгэсэн нь үгүй. Мөнхүү тэд эцгийн минь амийг

4а 1 Ниф. 10:4; 19:8.

5а 1 Ниф. 16:14;

С ба Г 17:1.

б су Лебен.

6а 1 Ниф. 9:1.

7а Ег. 20:25;

Дэд хууль 27:5–6.

б Эхл. 12:7–8; Ег. 24:4;

Абр. 2:17.

в су Талархалтай, Талархах, Талархал өргөх.

11а Сур. үгс 20:20.

б 1 Ниф. 5:2–4.

в 1 Ниф. 17:17.

су Бувтнах.

12а Мосе 4:6.

13а Иер. 13:14;

1 Ниф. 1:13.

хөнөөхөөр эрэлхийлсэн Иерусалим дахь иудейчүүдийн адил байсан бөлгөө.

14 Мөнхүү улиран тохиох дор миний эцэг Лемүелийн хөндийд Сүнсээр дүүргэгдэж, тэднийг өөрийн өмнө бүх бие нь “салгалан чичиртэл” хүчтэйгээр сургамжлав. Мөн, тэрээр тэднийг дуугарч зүрхлэхгүй болтол нь мадалж, иймийн тул, тэд түүний зарлигийг дагах болов.

15 Мөн, эцэг минь майханд аж төрөн байв.

16 Мөн улиран тохиох дор би, Нифай, үлэмж балчир бага хэдий ч, бие ханхар хийгээд Бурханы “нууцыг мэдэх асар их хүсэлтэй байсны учир, иймийн тул, би Их Эзэнд хандаж гуйн залбирав; мөн болгоогтун тэрбээр надад “зочлов, бас зүрх сэтгэлийг минь “зөөллөсний учир би “эцгийн ярьсан бүх үгсэд “итгэсэн авай; иймийн тул ах нарынхаа адил би түүнийг эсэргүүцсэн нь үгүй.

17 Мөн би Самд ярьж Их Эзэн Ариун Сүнсээрээ надад үзүүлсэн зүйлүүдийг түүнд мэдэгдэв. Мөнхүү улиран тохиох дор тэрбээр миний үгэнд итгэв.

18 Гэвч болгоогтун, Лемен,

Лемүел хоёр миний үгсийг дуулахгүй байсан болохоор тийнхүү тэдний зүрх сэтгэлийн хатуугийн улмаас “харамссаны учир би тэдний төлөө Их Эзэнд гуйн залбирлаа.

19 Ийнхүү улиран тохиох дор Их Эзэн надад хандаж, өгүүлэв: Адислагдсан буюу чи, Нифай, “итгэлийнхээ учир, зүрх сэтгэлийн номхон байдалд байж, намайг хичээнгүйлэн эрэлхийлсний учир болой.

20 Миний зарлигийг дагахын хэрээр та нар “дэгжиж, бас амлагдсан “нутаг тийш удирдагдах бөлгөө; тийм ээ, бүр та нарт зориулан миний бэлтгэсэн тэр нутагт; тийм ээ, нутаг бүгдээс дээгүүр сонгомол нутагт буюу.

21 Мөн ах нар чинь чамайг эсэргүүцэхийн хэрээр, тэд Их Эзэний дэргэдээс “тусгаарлагдах болно.

22 Мөн чи миний зарлигуудыг дагахын хэрээр, ах нарынхаа багш хийгээд “захирагч болгогдох ажгуу.

23 Учрыг болгоогтун, тэд намайг эсэргүүцэх тэр өдөр, би тэднийг “зүхнэ, бүр зовлонт зүхлээр, мөн түүнчлэн чиний үр удам намайг эсэргүүцээгүй цагт тэднийг тэд давамгайлах хүчгүй байх болно.

14a 1 Ниф. 17:45.

б су Хүч.

16a су Бурханы нууцууд.

б Дуул. 8:4;

Алма 17:10;

С ба Г 5:16.

су Илчлэлт.

в Хаад. дээд 18:37;

Алма 5:7.

г су Мөнх бус эцэг;

Бошиглогч.

д 1 Ниф. 11:5.

18a Алма 31:24;

3 Ниф. 7:16.

19a 1 Ниф. 7:12; 15:11.

20a Иош. 1:7;

1 Ниф. 4:14;

Мозая 1:7.

б Дэд хууль 33:13–16;

1 Ниф. 5:5; 7:13;

Моце 7:17–18.

су Амалтын нутаг.

21a 2 Ниф. 5:20–24;

Алма 9:13–15; 38:1.

22a Эхл. 37:8–11;

1 Ниф. 3:29.

23a Дэд хууль 11:28;

1 Ниф. 12:22–23;

С ба Г 41:1.

24 Мөн хэрэв тэд миний эсрэг хандвал, тэд чиний үр удамд “цээрлэл болон тэднийг дурсан сануулахаар” өдөөн хатгах болно.

БҮЛЭГ 3

Лихайн хөвгүүд гуулин ялтсуудыг олж авахаар Иерусалимд буцав—Лебен ялтсуудыг өгөхөөс татгалзав—Нифай ах нараа ухуулан бас зоригжуулав—Лебен тэдний эдийг тонож мөн тэднийг хөнөөхийг оролдов—Лемен, Лемүел хоёр Нифай болон Самыг цохиж мөн тэнгэр элчээс зэмлэл сонсов. Ойролцоогоор мээ 600–592 он.

Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, Их Эзэнтэй яриад, эцгийнхээ майханд буцаж ирэв.

2 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр надад хандаж өгүүлсэн нь: Болгоогтун чамайг болон ах нарыг чинь Иерусалимд буцахыг Их Эзэн надад зарлиг болгосон нэг “зүүдийг би зүүдлэв.

3 Учрыг болгоогтун, иудейчүүдийн цэдэг мөн түүнчлэн миний эцэг өвгөдийн “угийн бичиг Лебенд буй бөгөөд тэдгээр нь гуулин ялтсууд дээр сийлбэрлэгдсэн ажгуу.

4 Иймийн тул чи болон ах нар чинь Лебений гэрт очиж,

тэгээд ялтсуудыг эрэлхийлж, мөн аглаг буйд уруу нааш авчирвал зохино хэмээн Их Эзэн надад зарлигласан бөлгөө.

5 Мөн эдүгээ, болгоогтун ах нар чинь бувтналдаж тэднээс миний шаардсан зүйлийг хүнд бэрх гэгцгээв; гэвч болгоогтун тэднээс үүнийг шаардсан нь би биш, харин энэ бол Их Эзэний зарлиг.

6 Тиймийн тул яв, хүү минь, мөн чи “дургүйцээгүй учир Их Эзэний адислалыг чи хүртэх болно.

7 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, эцэгтээ хандаж хэлрүүн: Их Эзэн өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг тэдэнд “зэхэлгүйгээр хүмүүний үрст” зарлиг эс буулгана гэдгийг би мэдэх учраас би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно.

8 Мөнхүү улиран тохиох дор миний эцэг эдгээр үгсийг сонсоод туйлаас баярлав, миний бие Их Эзэнээр адислагдсаныг мэдсэний учир болой.

9 Мөнхүү би, Нифай, басхүү миний ах нар Иерусалимын нутаг өөд явахаар, майхнаа авч, аглаг буйд дахь аяны харгуйг дагав.

10 Мөнхүү улиран тохиох дор бид Иерусалимын нутаг

24а Иош. 23:13;
Шүүгч. 2:22–23.

б 2 Ниф. 5:25.

3 2а су Зүүд.

3а 1 Ниф. 5:14.

6а су Сүмийн
уидрагчдыг

дэмжих.

7а 1 Сам. 17:32;

Хаад, дээд 17:11–15.

су Итгэл;

Дуулгавартай байх,

Дуулгавартай,

Дуулгавартай дагах.

б су Бурханы
зарлигууд.

в Эхл. 18:14;

Филип. 4:13;

1 Ниф. 17:3, 50;

С ба Г 5:34.

өөд очоод, би болон ах нар маань өөр хоорондоо зөвшилцсөн болой.

11 Мөн бид “шавга орхин, Лебений гэрт хэн нь орвол зохихыг шодов. Мөнхүү улиран тохиох дор шавга Леменд тусав; тэгээд Лемен Лебений гэрт орж, түүнийг гэртээ сууж байхад нь түүнтэй ярилцсан болой.

12 Мөнхүү тэрээр миний эцгийн “угийн бичгийг агуулсан, гуулин ялтсууд дээр сийлэгдсэн тэрхүү цэдгийг Лебенээс хүссэн ажгуу.

13 Мөн болгоогтун, улиран тохиох дор Лебен уурлаж түүнийг дэргэдээсээ хөөн зайлуулав; мөн тэрээр уг цэдгүүдийг түүнд өгөхийг хүссэнгүй. Иймийн тул, тэрээр түүнд хандан: Болгоогтун, чи бол дээрэмчин, би чамайг хөнөөнө гэв.

14 Гэвч Лемен түүний дэргэдээс зугтан гарч, мөн бидэнд Лебений хэрхсэнийг хэлэв. Мөн бид ихэд харамсаж эхлэн, мөн ах нар маань аглаг буйдад буй эцэгтээ буцахыг завдав.

15 Гэвч болгоогтун, би тэдэнд хандан ийнхүү өгүүлэв: Их Эзэн амьдын адил, мөн бидний амьд нь илэрхийн адил, бид Их Эзэний зарлигласан зүйлийг гүйцэлдүүлэх хүртэл бид аглаг буйдад буй эцэг уруугаа очихоор явахгүй.

16 Иймийн тул, Их Эзэний зарлигийг дагахад итгэлийг хичээе, тиймийн тул эцгийнхээ “өвлөж ирсэн газрыг зорьё, учир нь болгоогтун, тэрбээр алт болон мөнгөө бас бүх баялгаа орхисон буюу. Мөн түүний үйлдсэн энэ бүхэн нь Их Эзэний “зарлигуудын улмаас болой.

17 Хүмүүсийн ёсон бусын учир, Иерусалим “устгагдах ёстойг тэрбээр мэдсэн ажгуу.

18 Учир нь болгоогтун, тэд бошиглогчдын үгсийг “эсэргүүцэв. Иймийн тул эцэг минь тэр нутгаас зугтан гар хэмээгдэн “зарлиглуулсныхаа дараа уг нутагт үлдсэн бол, болгоогтун, тэр ч бас эрсдэх байсан буйза. Иймийн тул тэрээр эл нутгаас зугтан гарах ёстой болсон ажгуу.

19 Мөн болгоогтун, эцэг өвгөдийн хэлийг үр хүүхдүүддээ хадгалуулан үлдээхийн тулд бид энэхүү “цэдгүүдийг олж авах нь Бурханы мэргэн ухаан буюу.

20 Мөн түүнчлэн бид энэ дэлхийн эхлэлээс бүр эдүгээ цагийг хүртэл, бүх ариун бошиглогчдын амаар тэдэнд хэлэгдсэн, Бурханы Сүнс болон хүч чадлаар тэдэнд хүргэгдсэн, тэдгээр үгсийг “өвлүүлэн үлдээхийн тулд болой.

21 Мөнхүү улиран тохиох дор Бурханы зарлигийг гүйцээх-

11a Нех. 10:34;

Үйлс 1:26.

12a 1 Ниф. 3:3; 5:14.

16a 1 Ниф. 2:4.

б 1 Ниф. 2:2; 4:34.

17a Шаст. дэд 36:16–20;

Иер. 39:1–9;

1 Ниф. 1:13.

18a су Эсэргүүцэл.

б 1 Ниф. 16:8.

19a Омнай 1:17;

Мозая 1:2–6.

20a су Судрууд—

Хадгалагдсан

судрууд.

дээ итгэлтэй байж болохын тул иймэрхүү маягийн хэлээр би ах нараа ятгав.

22 Мөнхүү улиран тохиох дор бид өвлөж ирсэн нутаг уруугаа очиж, мөн өөрсдийн “алт болон мөнгөө мөн үнэт зүйлсээ нэгтгэн цуглуулав.

23 Мөн бид эдгээр зүйлсийг цуглуулж авсныхаа дараа, бид Лебений гэрт буцаж очсон болой.

24 Мөнхүү улиран тохиох дор бид Лебэнд дахин очиж, мөн уг гуулин “ялтсууд дээр сийлэгдсэн цэдгүүдийг бидэнд өгөхийг түүнээс хүсээд, бид үүний төлөө түүнд өөрсдийн алт болон мөнгөө, мөн бүх үнэт зүйлсээ өгье хэмээв.

25 Мөнхүү улиран тохиох дор Лебен бидний эдийг, басхүү тэдгээрийн үлэмж агууг үзээд, тэрээр тэдгээрт “шүнаж, үүний хэрээр биднийг хөөж гарган, мөн тэр өөрөө эдийг маань эзэмдэхийн тулд биднийг хороолгохоор зарц нараа илгээв.

26 Мөнхүү улиран тохиох дор Лебений зарц нараас зугтан, мөн бид өөрсдийн эдийг ардаа орхихоос аргагүйд хүрсэн буюу, ингээд энэ нь Лебений гарт орох нь тэр.

27 Мөнхүү улиран тохиох дор бид аглаг буйд тийш зугтаж, тэгээд Лебений зарц нар биднийг эс гүйцэв, мөн бид өөрсдийгөө хадны хөндийд далдлан нуув.

28 Мөнхүү улиран тохиох дор Лемен надад, мөн түүнчлэн эцэгт минь уурлав; мөн түүнчлэн Лемүел ч, учир нь тэрээр Лемений үгсийг зөвшөөрөн дагах ажгуу. Иймийн тул Лемен, Лемүел хоёр бидэнд, дүү нартаа олон “хатуу үгсийг хэлж, биднийг занчив, бүр саваагаар болой.

29 Мөнхүү улиран тохиох дор тэд биднийг саваагаар занчиж ахуйд, болгоогтун, Их Эзэний “тэнгэр элч хүрэлцэн ирж тэдний өмнө зогсоод, мөн тэрээр тэдэнд хандаж өгүүлсэн нь: Та нар юуны учир дүүгээ саваагаар занчина? Та нарын алдсын учир Их Эзэн түүнийг та бүгдийн захирагч хэмээн сонгосныг та нар эс мэдэх бил үү? Болгоогтун, та нар Иерусалим өөд дахин одох болно, мөн Их Эзэн Лебенийг та нарын гарт оруулах болно.

30 Мөнхүү “тэнгэр элч бидэнд ярьсны дараа тэрээр одов.

31 Мөн эл тэнгэр элч одсоны дараа, Лемен, Лемүел дахин “бувтналдаж эхлэв, өгүүллрүүн: Их Эзэн Лебенийг бидний гарт оруулна гэдэг яахан боломжтой байх билээ? Болгоогтун, тэр чадалтай хүн, мөн тэр тавьд тушаал буулгаж чадах, тийм ээ, түүгээр ч үл барам тавийг хөнөөж чадах нэгэн; тэгвэл биднийг ч бас тэгэхгүй гэж үү?

22a 1 Ниф. 2:4.

24a 1 Ниф. 3:3.

25a су Шунах.

28a 1 Ниф. 17:17–18.

29a 1 Ниф. 4:3; 7:10.

су Тэнгэр элчүүд.

б 1 Ниф. 2:22.

30a 1 Ниф. 16:38.

31a су Бувтнах.

БҮЛЭГ 4

Нифай Их Эзэний зарлигаар Лебенийг хөнөөж, гуулин ялтсуудыг арга мэхээр гартаа оруулав — Зорам аглаг буйд дахь Лихайн гэрийнхэнтэй нэгдэхээр шийдэв. Ойролцоогоор мээ 600–592 он.

Мөнхүү улиран тохиох дор би ах нартаа хандаж, буцацгаая, мөн Их Эзэний зарлигуудыг сахихдаа “итгэлтэй байцгаая; учир нь болгоогтун тэрээр бүхий л дэлхийнхээс илүү чадалтай атал яахан Лебен болон түүний тавь, тийм ээ, эсвэл бүр түүний хэдэн арван мянгаас илүү ⁶чадалтай биш байх билээ?

2 Тиймийн тул бүгдээрээ өгсөн явцгаая; “Мосегийн адил ⁶хүчтэй байцгаая; учир нь тэрбээр үнэнээр Улаан ⁶тэнгисийн усанд хандан ярьсан бөгөөд тэр нь нааш цааш хуваагдан, ингээд бидний эцэг өвгөд дарангуйллаас ангижирч, хуурай газар дээгүүр хөндлөн гарч харин Фараоны их цэрэг дагаж орсон хэдий ч Улаан тэнгисийн усанд үйж үрэгдсэн буюу.

3 Эдүгээ болгоогтун энэ нь үнэнийг та нар мэднэ; мөн түүнчлэн “тэнгэр элч та нарт хандан ярьсаныг та нар мэднэ; иймийн тул та нар

эргэлзэж яахан чадна? Бүгдээрээ явцгаая; Их Эзэн биднийг бүр эцэг өвгөдийг минь чөлөөлсний адилаар чөлөөлж, бүр египетчүүдийг устгасны нэгэн адил, Лебенийг устгах чадалтай бөлгөө.

4 Эдүгээ намайг эдгээр үгсийг ярьсны дараа, тэд бас хилэгнэсээр, мөн үргэлжлэн бувтналдсаар байв; гэсэн хэдий ч Иерусалимын хэрмийн гадна иртэл тэд намайг дагасан буюу.

5 Мөнхүү энэ нь шөнөөр тохиов; мөн би тэднийг хэрмийн гадна өөрсдийгөө далдлан нуух болгов. Мөн тэднийг нуугдсаны дараа, би, Нифай, хотод сэм гэтэж ороод, Лебений гэрийг чиглэн явав.

6 Мөн би хийвэл зохих зүйлүүдийг урьдаас “мэдэхгүй байсны учир бибээр Сүнсэнд ⁶хөтлөгдөн байлаа.

7 Гэсэн хэдий ч би урагшлан явж, мөн бибээр Лебений гэрт дөхөж ирэх үедээ би нэгэн хүнийг ажиглав, мөн тэрээр дарсанд согтсоны учир миний өмнө газар унасан байв.

8 Мөн би түүн рүү хүрч очоод энэ нь Лебен байсныг олж мэдсэн бөлгөө.

9 Мөнхүү бибээр түүний “илдийг ажин, би тэрнийг хуйнаас нь сугалав; мөн бариул

4 1а су Зориг, Зоригтой; Итгэл.
б 1 Ниф. 7:11–12.
2а су Мосе.
б Дэд хууль 11:8.
в Ег. 14:21;

1 Ниф. 17:26;
Мозая 7:19.
3а 1 Ниф. 3:29–31; 7:10.
6а су Ариун Сүнс;
Сүнсний
удирдамж,

Сүнслэгээр
нөлөөлөгдөх.
б Евр. 11:8.
9а 2 Ниф. 5:14;
С ба Г 17:1.

нь шижир алт, бас ур хийц нь үлэмж сайн, бас ир нь хамгийн үнэт болд байхыг харсан буюу.

10 Мөнхүү улиран тохиох дор бибээр Лебенийг албал зохино хэмээн Сүнсээр “албадуулав; гэвч би зүрх сэтгэлдээ хэлрүүн: Хэзээ ч ямар ч цагт би хүний цус урсгасан нь үгүй. Бас би зайлсхийн мөн түүнийг устгахгүй байж болох биш үү хэмээв.

11 Мөн Сүнс дахин надад хандаж: Болгоогтун, “Их Эзэн түүнийг чиний гарт оруулсан болой хэмээв. Тийм ээ, мөн тэрээр миний амийг авахаар эрэлхийлснийг би мэдсэн билээ; тийм ээ, тэр Их Эзэний зарлигуудыг дуулахгүй байв; мөн тэр бидний эд хөрөнгийг ^бсалган авсан билээ.

12 Мөнхүү улиран тохиох дор Сүнс надад дахин хандан: Их Эзэн түүнийг чиний гарт оруулсан учир түүнийг устга хэмээв.

13 Их Эзэн зөв шударга зорилгоо гүйцэлдүүлэхийн тулд “эсон бус тэднийг ^бхөнөөдгийг болгоогтун. Нэгэн үндэстэн бууран доройтож мөн итгэлгүйдээ мөхсөнөөс нэг хүн эрсэдсэн нь ^бдээр буюу.

14 Мөн эдүгээ, Нифай, би эдгээр үгсийг сонссоны дараа, Их Эзэн надад хандан: Чиний

үр сад миний “зарлигийг дагахын ^бхэрээр тэд амлалтын “нутагт ^ддэгжих болно хэмээн аглаг буйдад ярьсан үгсийг саналаа.

15 Тийм ээ, мөн түүнчлэн тэдэнд Мосегийн хууль байхгүйн улмаас уг хуулийн дагуу тэд Их Эзэний зарлигуудыг дагаж чадахгүйд хүрэх буюу хэмээн би сэтгэв.

16 Мөн түүнчлэн би уг “хууль гуулин ялтсууд дээр сийлэгдсэнийг мэдсэн бөлгөө.

17 Мөн үүнчлэн түүний зарлигуудын дагуу би цэдгүүдийг олж авч болохын учир—энэ шалтгааны улмаас Их Эзэн, Лебенийг миний гарт өгснийг мэдсэн буюу.

18 Тиймийн тул би Сүнсний дуу хоолойг дагаж Лебений толгойн үснээс татан, өөрийнх нь “илдээр би түүний толгойг тас цавчив.

19 Мөнхүү би түүний толгойг өөрийнх нь илдээр цавчсаны дараа, би Лебений хувцсыг авч, өөрийн биед өмсөв; тийм ээ, бүр нэг бүрчлэн; мөн би түүний хуягийг авч биедээ агсав.

20 Мөн би үүнийг хийсний дараа, би Лебений сан хөмрөгийг чиглэн явлаа. Тийнхүү би Лебений сангийн зүг явж байхдаа, болгоогтун, Лебений “зарц, сангийн түлхүүрийг баригч түүнийг би харав. Мөн

10a Алма 14:11.

11a 1 Сам. 17:41–49.

б 1 Ниф. 3:26.

13a 1 Ниф. 17:33–38;

С ба Г 98:31–32.

б су Ёс бус, Ёс бус явдал.

в Алма 30:47.

14a Омнаи 1:6;

Мозая 2:22;

Ифер 2:7–12.

б су Бурханы зарлигууд.

в 1 Ниф. 2:20.

г 1 Ниф. 17:13–14;

Иаков 2:12.

16a су Мосегийн хууль.

18a 1 Сам. 17:51.

20a 2 Ниф. 1:30.

би түүнд Лебений дуугаар, түүнийг надтай хамт санд очвол зохино хэмээн тушаалаа.

21 Мөн тэр миний хувцас болон түүнчлэн хэвлийн тус бүсэлсэн илдийг харсан учир тэрбээр намайг өөрийн эзэн Лебен хэмээн бодсон байв.

22 Мөн тэрээр надад хандан иудейчүүдийн ахлагчдын тухай ярьж байв, тэрээр түүний эзэн, Лебен, шөнөөр тэдний дунд байсныг мэдэж байсны учир болой.

23 Мөн би түүнд хандан Лебен байсан мэтээр ярьж байлаа.

24 Мөнхүү түүнчлэн би түүнд хандан би гуулин “ялтсууд дээр хийгдсэн тэр сийлбэрийг хэрмийн гадна буй ах нартаа аваачих ёстой хэмээн ярьсан болой.

25 Мөн түүнчлэн намайг дагахыг би түүнд тушаасан буюу.

26 Мөн тэрээр намайг сүм дэх ах нарынхаа тухай ярьж буй бөгөөд намайг үнэхээр миний алсан тэрхүү Лебен хэмээн бодсон буюу, иймийн тул тэрбээр намайг дагасан авай.

27 Мөн тэрбээр надад хандан намайг хэрмийн гадна буй ах нартаа очихоор явах зуур иудейчүүдийн ахлагчдын талаар олон удаа ярьсан бөлгөө.

28 Мөнхүү улиран тохиох дор Лемен намайг хараад машид айв, мөн Лемүел болон Сам ч бас адил. Мөн тэд миний

бараанаар зугтаан одов; учир нь тэд энэ нь Лебен байж мөн тэр намайг алаад бас тэдний амийг авахаар эрэлхийлж буй хэмээн бодсон ажээ.

29 Мөнхүү улиран тохиох дор би тэдний араас дуудав, мөн тэд намайг сонсов; иймийн тул тэд миний дэргэдээс зугтаахаа орхив.

30 Мөнхүү улиран тохиох дор Лебений зарц ах нарыг минь хараад дагжиж эхлэв, мөн тэрээр миний хажуугаас зугтан бас Иерусалим хотод буцахыг завдав.

31 Мөн эдүгээ би, Нифай, бие томтой, түүнчлэн Их Эзэнээс ихээхэн “чадлыг авсан тул, тиймийн тул би Лебений зарцыг барин авч, түүнийг зугтаалгахгүйн тул хориглон байсан болой.

32 Мөнхүү улиран тохиох дор би түүнд хэрэв тэрээр миний үгийг сонсвоос, Их Эзэн амьдын адил мөн би ч амьд буйн адилаар, тэрчлэн хэрэв тэрээр бидний үгсийг дуулбал, бид түүний амийг өршөөнө хэмээн өгүүлэв.

33 Ингээд би түүнд хандан, түүнийг айх хэрэггүй хэмээн бүр “ам алдав; хэрэв тэр бидэнтэй хамт аглаг буйд уруу явбал бидний адил чөлөөт хүн болно хэмээн хэлэв.

34 Мөн түүнчлэн би түүнд хандаж хэлрүүн: Их Эзэн энэ зүйлийг хийлгэхээр бидэнд “зарлигласан нь дамжиггүй; мөн бид Их Эзэний

зарлигуудыг биелүүлэхээр чармайх ёсгүй гэж үү? Тиймийн тул, хэрэв та аглаг буйд тийш, эцэгт минь очвол бидний дунд орших байр танд байх болно.

35 Мөн улиран тохиох дор “Зорам миний ярьсан үгэнд зоригжив. Эдүгээ Зорам гэдэг нь уг зарцын нэр ажгуу; мөн тэрээр аглаг буйд тийш одож бидний эцэгт очно хэмээн амлав. Тийм ээ, мөн түүнчлэн тэр цагаас эхлэн бидэнтэй үлдэнэ хэмээн тэр бидэнд тангараг тавив.

36 Эдүгээ бид түүнийг өөрсөдтэйгөө хамт үлдээхийг хүссэн нь иудейчүүд аглаг буйд тийш бидний дүрвэснийг мэдэхгүй байж магад, тэд биднийг мөшгөж мөн биднийг устгах болуузай хэмээсний учир бөлгөө.

37 Мөнхүү улиран тохиох дор Зорамыг бидэнд “тангараг тавихад, түүний талаарх бидний айдас замхрав.

38 Мөнхүү улиран тохиох дор бид гуулин ялтсуудыг бас Лебений зарцыг авч, аглаг буйд тийш одож, эцгийн майхны зүг аяны мөр хөөв.

БҮЛЭГ 5

Сариа Лихайн эсрэг үглэн гомдоллов— Хөвгүүдийнхээ эргэж ирсэнд хоёул баясав— Тэд тахил өргөв— Уг гуулин ялтсууд Мосе болон бошиглогчдын бичиглэлийг

агуулжээ— Уг ялтсууд Лихайг Иосефын үр удам гэдгийг таниулав— Лихай өөрийн үр удмын талаар мөн ялтсуудыг хадгалах талаар бошиглов. Ойролцоогоор мээ 600–592 он.

Мөнхүү улиран тохиох дор бид аглаг буйдад эцэгтээ ирсний дараа, болгоогтун, тэрбээр баяр хөөрөөр дүүргэгдсэн байв, мөн түүнчлэн миний эх “Сариа, үлэмж хангалуун байв, учир нь тэрээр бидний төлөө үнэхээр гацуудан байсан ажгуу.

2 Учир нь тэр биднийг аглаг буйдад үрэгдсэн хэмээн бодсон ажээ; мөн тэрээр эцгийн минь эсрэг үглэн гомдоллож, тэр зөнч хүн байсныг нь түүнд дурдан; хэлсэн нь: Болгоогтун та биднийг өвлөж ирсэн нутгаас минь дагуулан гаргасан буюу, ингээд хөвгүүд минь үгүй болов, мөн бид аглаг буйдад үрэгдэх буюу.

3 Мөн эх минь эцгийн минь эсрэг үглэн иймэрхүү маягийн хэлээр гомдоллосон байв.

4 Мөнхүү улиран тохиох дор эцэг минь түүнд хандаж, хэлсэн нь: Би “зөнч хүн гэдгээ мэднэ; хэрэв би Бурханы зүйлүүдийг ⁶үзэгдэлд хараагүйсэн бол би Бурханы сайн сайхныг мэдэхгүй байх байсан, харин Иерусалимд хоргодон, ах дүүстэйгээ хамт хөнөөгдөх байсан биз ээ.

35a 1 Ниф. 16:7;
2 Ниф. 5:5–6.
су Зорам,
зорамчууд.

37a Иош. 9:1–21;
Ном. үгс 5:4.
су Тангараг.
5 1a су Сариа.

4a 1 Ниф. 2:11.
б 1 Ниф. 1:8–13.
су Үзэгдэл.

5 Гэвч болгоогтун, би амлалтын “нутгийг олж авлаа, үүн дээр би, эдгээр зүйлүүдэд баясна; тийм ээ, мөн Их Эзэн хөвгүүдийг минь Лебений савраас зайлуулна, мөн тэднийг авчлаа буйдад бидэнд дахин авчирна гэдгийг би ^бмэднэ.

6 Мөн иймэрхүү маягийн хэлээр миний эцэг Лихай, эх Сариаг бидний тухайд тайтгаруулан байв, биднийг иудейчүүдийн цэдгийг олж авахаар, Иерусалимын газар өөд аглаг буйдад аялах зуур болой.

7 Мөн биднийг эцгийнхээ майханд эргэж ирэхэд, болгоогтун тэдний баяр хөөр дүүрч, мөн эх минь тайтгаруулагдав.

8 Мөн тэрээр ярьж, хэлсэн нь: Эдүгээ Их Эзэн миний эр нөхөрт аглаг буйд тийш зугтаа хэмээн “зарлигласныг би баттай мэдэв; тийм ээ, мөн түүнчлэн Их Эзэн хөвгүүдийг минь хамгаалж, бас Лебений савраас зайлуулсныг мөн Их Эзэн тэдэнд зарлигласан зүйлийг ^бгүйцэлдүүлж чадах хүчийг тэдэнд өгснийг би баттай мэдэв. Мөн тэрээр иймэрхүү маягийн хэлээр ярив.

9 Мөнхүү улиран тохиох дор

тэд үлэмж ихээр баясан, тэгээд Их Эзэнд “тахил өргөж мөн өргөл хайлав; мөн тэд Израилын Бурханд ^бталархлаа дэвшүүлсэн болой.

10 Мөн тэд Израилын Бурханд хандан талархлаа дэвшүүлсний эцэст, миний эцэг, Лихай, гуулин “ялтсууд дээр сийлэгдсэн тэрхүү цэдгийг авч, мөн тэрбээр тэдгээрийг эхнээс нь судалсан авай.

11 Мөн тэрээр тэдгээрт дэлхийн үүслийн, мөн түүнчлэн бидний анхны эцэг эх болсон Адам Ева хоёрын тухай шастырыг багтаасан Мосегийн таван “ном агуулагдсаныг болгоов.

12 Мөн түүнчлэн эхлэлээс бүр Иудейн хаан, Зедикаягийн засаглалын эхлэл хүртэлх иудейчүүдийн “цэдгийг буюу.

13 Мөн түүнчлэн ариун бошиглогчдын бошиглолууд нь эхлэлээс, бүр “Зедикаягийн хаанчлалын үүслийг хүртэл; мөн түүнчлэн ^бИеремиагийн амаар яригдсан олон бошиглолыг бөлгөө.

14 Мөнхүү улиран тохиох дор миний эцэг Лихай түүнчлэн гуулин “ялтсууд дээрээс эцэг өвгөдийнхөө угийн бичгийг олов; иймийн

5а 1 Ниф. 2:20; 18:8, 22–23.

сү Амлалтын нутаг.

б сү Итгэл.

8а 1 Ниф. 2:2.

б 1 Ниф. 3:7.

9а Мозая 2:3;

3 Ниф. 9:19–20.

сү Мосегийн хууль.

б сү Талархалтай, Талархах, Талархал өргөх.

10а 1 Ниф. 4:24, 38; 13:23.

сү Гуулин ялтсууд.

11а 1 Ниф. 19:23.

сү Пентатеух.

12а Шаст. дээд 9:1.

сү Судрууд.

13а Хаад. дэд 24:18; Иер. 37:1.

б Езра 1:1;

Иер. 36:17–32;

1 Ниф. 7:14;

Хил. 8:20.

14а 1 Ниф. 3:3, 12.

сү Гуулин ялтсууд.

тул тэрээр ⁶Иосефын удам байсныг мэдсэн ажээ; тийм ээ, бүр ⁶Иаковын хүү асан тэр, Египетэд худалдагдсан тэр, мөн өөрийн эцэг Иаков, түүний бүхэл өрх гэрийг өлсгөлөнгийн аюулаас ⁶хамгаалж болно хэмээн Их Эзэний мутраар хадгалагдан хамгаалагдсан тэрхүү Иосеф болой.

15 Мөн түүнчлэн тэднийг хамгаалсан мөнхүү тэр Бурханаар удирдагдан тэд Египет нутгаас мөн дарангуйллаас “гарсан бөлгөө.

16 Мөнхүү тийн миний эцэг, Лихай, эцэг өвгөдийнхөө уг удмыг мэдэж авсан ажгуу. Мөн түүнчлэн Лебен ч бас “Иосефын удам байж, иймийн тул тэр мөн өөрийн эцэг өвгөдийн цэдгийг хадгалж байжээ.

17 Мөн эдүгээ эцэг минь эдгээр бүх зүйлийг хараад, тэрээр Сүнсээр дүүргэгдэв, мөн үр удмынхаа тухай бошиглож эхлэв—

18 Эдгээр гуулин ялтсууд түүний үр удам болох бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүст очно гэдгийг болой.

19 Иймийн тул, эдгээр гуулин ялтсууд “хэзээ ч үрэгдэх учиргүй; цагийг даган бүдгэрэх нь ч бас үгүй хэмээн тэр хэлэв. Мөн тэрээр үр

удмынхаа тухай олон зүйлийг бошиглов.

20 Мөнхүү улиран тохиох дор өдий хүртэл бидэнд зарлигласан Их Эзэний зарлигуудыг миний эцэг гүйцэлдүүлсэн болой.

21 Мөн бид Их Эзэн бидэнд зарлигласнаар цэдгүүдийг олж, мөн тэдгээрийг судалж мөн тэдгээр нь хүсүүштэй болохыг олж мэдэв; тийм ээ, бүр үр хүүхдүүддээ Их Эзэний зарлигуудыг “сахиулан өвлүүлэхүйц агуу ⁶эрхэм чухал ажгуу.

22 Иймийн тул амлалтын нутгийг зорин аглаг буйдад зорчихдоо, бид эдгээрийг өөрсөдтэйгөө авч явах нь Их Эзэний мэргэн ухаан буйза.

БҮЛЭГ 6

Бурханы зүйлүүдийн тухай Нифай бичиглэв—Нифайн зорилго нь Абрахамын Бурханд ирж мөн аврагдахыг хүмүүнд ятгах байв. Ойролцоогоор мээ 600–592 он.

Мөн эдүгээ би, Нифай, цэдгийнхээ “энэ хэсэгт эцэг өвгөдийнхөө угийн бичгийг хожим нэгэн цагт би өөрийн бичиглэн буй эдгээр ⁶ялтсууд дээр буулгах нь ч үгүй; энэ нь миний ⁶эцгийн хадгалж

14б 2 Ниф. 3:4;
Алма 10:3.
су Иосеф, Иаковын хүү.
в су Иаков,
Исаакийн хүү.
г Эхл. 37:29–36.
д Эхл. 45:4–5.

15а Ег. 13:17–18;
Амос 3:1–2;
1 Ниф. 17:23–31;
С ба Г 103:16–18;
136:22.
16а 1 Ниф. 6:2.
19а Алма 37:4–5.
21а 2 Ниф. 25:26.

б су Судрууд—Судруудын үнэ цэнэ.
6 1а 2 Ниф. 4:14–15.
б 1 Ниф. 9:2.
в 1 Ниф. 1:16–17;
19:1–6.

байсан тэрхүү цэдэгт буйн учир болой; иймийн тул би энэ дэвтэрт үүнийг бичиглэхгүй бөлгөө.

2 Тухайлбал бид “Иосефын удам гэдгийг хэлэх нь миний хувьд хангалттай.

3 Мөн бибээр эцгийнхээ бүхий л зүйлийг бүрэн тодорхой тэмдэглэхийг чухалчилсангүй, учир нь, тэдгээр нь “эдгээр ялтсууд дээр бичигдэж чадахгүй, учир нь, би Бурханы зүйлүүдийн тухай бичиж болох тийм зайг би хүсч байна.

4 Учир нь, миний бүхий л зорилго бол Абрахамын Бурхан, мөн Исаакийн Бурхан, мөн Иаковын Бурханд “ирж, аврагд хэмээн хүмүүнд ^бятгах нь болой.

5 Иймийн тул, би дэлхийд “таалагдах зүйлүүдийг бус, харин Бурханы таалалд мөн дэлхийд үл харьяалагдах тэдний таалалд нийцэх зүйлүүдийг бичиглэх болой.

6 Иймийн тул, хүмүүний үрст эрхэм чухал бус зүйлүүдээр эдгээр ялтсуудыг дүүргэх ёсгүй хэмээн би үр удамдаа зарлиглах болно.

БҮЛЭГ 7

Лихайн хөвгүүд Иерусалим уруу буцаж мөн Ишмэил болон түүний гэрийнхнийг тэдний аянд

нэгдэхийг урив—Лемен болон зарим нь эсэргүүцэв—Нифай Их Эзэнд итгэлтэй байхыг ах нартаа ухуулав—Тэд түүнийг олсоор хүлж, түүнийг бүрэлгэхээр төлөвлөв—Тэрээр итгэлийн хүчээр суллагдав—Ах нар нь өршөөл гуйв—Лихай болон түүний аяныхан тахил өргөж мөн өргөл хайлав. Ойролцоогоор мээ 600–592 он.

Мөн эдүгээ, миний эцэг, Лихай, үр удмынхаа талаар “бошигლოსны дараа, мөнхүү улиран тохиох дор Их Эзэн түүнд хандан дахин ярьж, Лихай, зөвхөн өөрийн гэр бүлийг авч аглаг буйд тийш зорчих нь зохистой биш болой; харин тэр амлагдсан нутагт Их Эзэний төлөө үр удмаа өсгөж болохын тулд, хөвгүүд чинь ^бохидыг “эхнэр болгон авбал зохилтойг та нар мэдээсэй хэмээнэ би.

2 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай түүнчлэн миний ах нар Иерусалим газарт дахин буцаж, тэгээд Ишмэил болон түүний гэр бүлийг аглаг буйдад авчирвал зохилтой хэмээн Их Эзэн түүнд “зарлигласан болой.

3 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, ах нарынхаа хамт Иерусалим өөд зорин аглаг буйд тийш “дахин зорчив.

4 Мөнхүү улиран тохиох дор бид Ишмэилийн гэрт

2а 1 Ниф. 5:14–16.

3а Иаков 7:27;

Жером 1:2, 14;

Омнаи 1:30.

4а 2 Ниф. 9:41, 45, 51.

б Иохан 20:30–31.

Мормоны Номны
эхний хуудсыг үз.

5а 1 Тес. 2:4;

Мор. үгс 1:4.

7 1а 1 Ниф. 5:17–19.

б 1 Ниф. 16:7.

в су Гэрлэлт, Гэрлэх.

2а 1 Ниф. 16:7–8.

3а 1 Ниф. 3:2–3.

хүрч очоод, бид Ишмэилийн зүгээс тааллыг олж, үүнийхээ хэрээр түүнд хандан Их Эзэний үгсийг ярьсан ажгуу.

5 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Ишмэилийн зүрхийг зөөллөсөн буюу, мөн түүнчлэн түүний гэрийнхнийх нь ч, үүний дүнд тэд бидэнтэй хамт эцгийн маань майхан уруу зорин аглаг буйдад аянд гарваа.

6 Мөнхүү улиран тохиох дор бид аглаг буйдад зорчих зуур, болгоогтун, Лемен болон Лемүел, мөн Ишмэилийн охидоос хоёр нь, мөн Ишмэилийн хоёр “хүү болон тэдний гэр бүлийнхэн, биднийг эсэргүүцэв; тийм ээ, Нифай миний эсрэг болон Сам, мөн тэдний эцэг Ишмэил, мөн түүний эхнэр, мөн түүний бусад гурван охины эсрэг бөлгөө.

7 Мөнхүү улиран тохиох дор уг эсэргүүцэл нь тэд Иерусалимын нутагт буцахыг хүссэнээс болой.

8 Мөн эдүгээ би, Нифай, тэдний зүрх сэтгэл хатуугийн учир “харамсан байв, тиймийн тул би тэдэнд хандан ярьж, хэлрүүн, тийм ээ, бүр Леменд мөн Лемүелд хандан: Болгоогтун, та нар миний ах нар, тэгээд та нар яахан зүрх сэтгэлээрээ ийм хатуу, мөн оюун тань ийм харалган билээ, тиймээс ч би, та нарын

дүү атал, та нарт хандан ярих ёстой болж, тийм ээ, мөн та нарт үлгэрлэх хэрэг үү?

9 Та нар Их Эзэний үгийг яахан эс дуулав?

10 Та нар Их Эзэний тэнгэр элчийг харснаа яахан “мартсан билээ?

11 Тийм ээ мөн Их Эзэн биднийг Лебений савраас “чөлөөлж, мөн түүнчлэн бид цэдгийг авах болсон зэрэг бидний тул хийсэн үлэмж агуу зүйлүүдийг та нар яахан мартаж болов?

12 Тийм ээ, мөн хэрэв тэд тийнхүү байж “итгэлээ бодитой болговол бүх ⁶зүйлийг Их Эзэн хүмүүний үрсийн төлөө өөрийн ёсоор болгож болно гэдгийг та нар яахан мартаж болов? Иймийн тул түүнд итгэлтэй байцгаая.

13 Мөн хэрэв бид ийнхүү байж түүнд итгэлтэй байвал, бид амлалтын “нутагт хүрэх болно; мөн та нар ирээдүйн нэгэн үед Иерусалимын устгалын тухай Их Эзэний үг гүйцэлдэхийг мэдэх болно; учир нь Иерусалимын ⁶устгалын талаар Их Эзэний ярьсан тэр бүх зүйл биелэгдэх ёстой.

14 Учир нь болгоогтун, Их Эзэний Сүнс тэдний төлөө хичээхээ удахгүй болино; учир нь болгоогтун, тэд бошиглогчдыг “эсэргүүцэж, мөн ⁶Иеремиаг гянданд хая-

6a 2 Ниф. 4:10.

8a Алма 31:2;

Моце 7:41.

10a Дэд хууль 4:9;

1 Ниф. 3:29; 4:3.

11a 1 Ниф. 4.

12a 1 Ниф. 3:7; 15:11.

б 1 Ниф. 17:50;

Алма 26:12.

13a 1 Ниф. 2:20.

су Амлалтын нутаг.

б Хаад. дэд 25:1–21;

2 Ниф. 6:8; 25:10;

Омнаи 1:15;

Хил. 8:20–21.

14a Езек. 5:6;

1 Ниф. 1:18–20; 2:13.

су Эсэргүүцэл.

б Иер. 37:15–21.

сан болой. Мөн тэд эцгийн минь “амийг авахаар эрэлхийлж, үүний хэрээр түүнийг нутгаасаа зугтан гарахад хүргэсэн буюу.

15 Эдүгээ болгоогтун, хэрэв та нар Иерусалим уруу буцвал та нар ч бас тэдэнтэй хамт хөнөөгдөх болно хэмээн би та нарт хэлж байна. Мөн эдүгээ, хэрэв та нар сонгосон бол, тэр газар өөд яв, тэгээд хэрэв та нар явбаас та нар ч түүнчлэн хөнөөгдөнө хэмээн та нарт миний ярьсан үгсийг санагтун; эдгээр нь Их Эзэний Сүнс ярих ёстой хэмээн намайг албадаж байгаагаас буюу.

16 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, эдгээр үгсийг ах нартаа хандан ярьсны дараа, тэд надад уурлаж байв. Мөнхүү улиран тохиох дор тэд надад гар хүрэв, учир нь болгоогтун, тэд үлэмж ихээр хилэгнэн, мөн тэд намайг олсоор “хүлэв, тэд намайг зэрлэг араатанд тасчуулахаар аглаг буйдад орхиж болно хэмээн амийг минь бүрэлгэхээр эрэлхийлсний учир болой.

17 Гэвч улиран тохиох дор би Их Эзэнд залбирч, хэлсэн нь: Ай Их Эзэн танд итгэх миний итгэлийн улмаас, та намайг ах нарын минь гараас зайлуулаач; тийм ээ, намайг хүлсэн энэ хүлээсийг “тасар татах хүчийг өгөөч надад.

18 Мөнхүү улиран тохиох дор намайг эдгээр үгсийг хэлмэгц, болгоогтун, хүлээс гар

болон хөлөөс минь алдуурав, мөн би ах нарынхаа өмнө зогсож, бас тэдэнд хандан дахин ярив.

19 Мөнхүү улиран тохиох дор тэд дахин надад уурлаж, мөн надад гар хүрэхийг завдав; гэвч болгоогтун, Ишмэилийн “охидоос нэг нь, тийм ээ, мөн түүнчлэн түүний эх, мөн Ишмэилийн хөвгүүдийн нэг нь, ах нараас маань хичээнгүйлэн гуйхын хэрээр тэдний зүрхийг зөөллөв; мөн тэд амийг минь авахаар оролдохоо болив.

20 Мөнхүү улиран тохиох дор тэд өөрсдийн ёсон бусын улмаас харамсан байв, үүний хэрээр тэд миний өмнө бөхийж, мөн миний эсрэг үйлдсэн зүйлийг өршөөхийг тэд надаас гуйв.

21 Мөнхүү улиран тохиох дор тэдний хийсэн бүгдийг би даруй “уучилж, мөн тэд Их Эзэн Бурхандаа хандан өршөөлийн тул залбир хэмээн тэднийг би ухуулав. Мөнхүү улиран тохиох дор тэд тийн үйлдэв. Мөн тэд Их Эзэнд залбирсны эцэст бид дахин эцгийнхээ майхны зүг зорин аяндаа гарсан буюу.

22 Мөнхүү улиран тохиох дор бид эцгийнхээ майханд ирэв. Мөн би болон ах нар маань бас Ишмэилийн бүх гэрийнхэн эцгийн маань майхан уруу ирсний дараа, тэд Их Эзэн Бурхандаа “талархал дэвшүүлэв; мөн тэд

14в 1 Ниф. 2:1.

16а 1 Ниф. 18:11–15.

17а Алма 14:26–28.

19а 1 Ниф. 16:7.

21а су Уучлах.

22а су Талархалтай,

Талархах, Талархал өргөх.

түүнд ^бтахил өргөн мөн өргөл хайлав.

БҮЛЭГ 8

Лихай амьдралын модыг үзэгдэлд харав— Тэрээр жимснээс нь хүртэж мөн өөрийн гэр бүлийг тэрчлэн үйлдэхийг хүсэв— Төмөр баршул, давчуу бөгөөд нарийн зам, мөн хүмүүсийг бүрхэх харанхуй мананг тэр харав— Сариа, Нифай, Сам нар жимснээс хүртэж, харин Лемеен Лемүел хоёр татгалзав. Ойролцоогоор мэв 600–592 он.

Мөнхүү улиран тохиох дор бид бүхий л зүйлийн үрийг төрөл бүрээр, зүйл бүрийн үр тарианы, мөн түүнчлэн зүйл бүрийн жимсний үрийг аль алиныг нь нэгтгэн цуглуулав.

2 Мөнхүү улиран тохиох дор эцэг минь аглаг буйдад саатан байх зуур тэрээр бидэнд хандан ярьж, өгүүлсэн нь: Болгоогтун, би зүүд “зүүдлэв; эсвээс, өөрөөр хэлбэл, би ^бүзэгдэл үзэв.

3 Мөн болгоогтун, би үзсэн зүйлийнхээ учир, Их Эзэнд баясах шалтгаан надад буй нь “Нифай болон түүнчлэн Самын тул бөлгөө; учир нь тэд болон тэдний үр удмаас олон нь аврагдана гэж бодох шалтгаан надад буй.

4 Гэвч болгоогтун, “Лемеен

Лемүел хоёр, би та нарын төлөө үлэмж ихээр айна; учир нь болгоогтун, миний ухаарснаар би зүүдэндээ бүрэнхий мөн дүнсгэр аглаг буйдыг харсан болой.

5 Мөнхүү улиран тохиох дор би цагаан “орхимж өмссөн нэгэн хүмүүнийг харав; мөн тэрбээр ирж бас миний өмнө зогсов.

6 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр надад хандан ярьж, мөн түүнийг дагахыг надад тушаав.

7 Мөнхүү улиран тохиох дор би түүнийг дагаад өөрийгөө бүрэнхий мөн дүнсгэр ээлүүдэд байгааг би ажив.

8 Мөн би харанхуйд олон цагийн турш зорчсоны эцэст би Их Эзэнд хандан түүний эрхэм их нигүүлслийн улмаас намайг “нигүүлсэн үзэхийг хүсэн залбирч эхэлсэн буюу.

9 Мөнхүү улиран тохиох дор би Их Эзэнд хандан залбирсны эцэст би уудам болоод цэлгэр “талбарыг ажиглав.

10 Мөнхүү улиран тохиох дор хүртсэн нэгнийг жаргалтай болгох дур булаам “жимстэй нэгэн ^бмодыг би харсан бөлгөө.

11 Мөнхүү улиран тохиох дор би урагшлан түүний “жимснээс хүртэв; мөн энэ нь урьд өмнө миний амсаж асан бүхнээс дээгүүр тэргүүн амтат

22б 1 Ниф. 5:9.

8 2а су Зүүд; Илчлэлт.

б 1 Ниф. 10:17.

су Үзэгдэл.

3а 1 Ниф. 8:14–18.

4а 1 Ниф. 8:35–36.

5а ИС—Т 1:30–32.

8а су Нигүүлсэнгүй,
Нигүүлсэл.

9а Мат. 13:38.

10а Алма 32:41–43.

б Эхл. 2:9;

Илч. 2:7; 22:2;

1 Ниф. 11:4, 8–25.

су Амьдралын мод.

11а Алма 5:34.

байсныг би болгоосон бөлгөө. Тийм ээ мөн түүний жимс нь цагаан, урьд өмнө миний үзсэн бүхнээс үлэмж ^бцагаан байсныг би болгоов.

12 Мөн би түүний жимснээс хүртэхийн сацуу энэ нь миний сэтгэлийг үлэмж агуу “баяраар дүүргэв; иймийн тул, гэр бүлийнхэн маань үүнээс түүнчлэн хүртээсэй хэмээн би ^бхүсч эхлэв; би энэ нь бүхий л жимснээс дээгүүр “дур булаам болохыг бибээр мэдсэний учир буюу.

13 Мөн түүнчлэн гэр бүлийнхнээ олж болзошгүй хэмээн би эргэн тойрон хараа бэлчээвээс, нэгэн уст “голыг олж харав би; мөн энэ нь жимснээс нь миний хүртсэн тэр модны дэргэдүүр урсах ажгуу.

14 Мөн би үүнийг хаанаас эхтэйг нь ажиглан харав; мөн үүний эх нь ялимгүй цаана байхыг үзэв; мөн үүний эхэн дээр та нарын эх Сариа, мөн Сам болон Нифайг харав; мөн тэд хааш одвол зохихыг мэдэхгүй зогсож байсан болой.

15 Мөнхүү улиран тохиох дор би тэднийг даллав; мөн түүнчлэн би тэдэнд хандан өндөр дуугаар тэднийг надад ирж, мөн бүхий л жимснээс дээгүүр хүсэл татам тэр жимснээс хүртвэл зохино хэмээн хэлсэн бөлгөө.

16 Мөнхүү улиран тохиох дор тэд надад ирж, мөн жимснээс түүнчлэн хүртсэн авай.

17 Мөнхүү улиран тохиох дор Лемен болон Лемүел хоёрыг ирж мөн түүнчлэн жимснээс хүртээсэй хэмээн би хүсэв; иймийн тул, би тэднийг харж магад хэмээн голын эхэн тийш хараа бэлчээв.

18 Мөнхүү улиран тохиох дор би тэднийг харав, гэвч тэд надад ирж жимснээс хүртсэн нь “үгүй бөлгөө.

19 Мөн би төмөр “бариулыг харав, мөн энэ нь голын эргийн дагуу сунан үргэлжилсэн бөгөөд дэргэд нь миний зогсох тэр модны зүг удирдсан авай.

20 Мөн түүнчлэн уг төмөр бариулыг дагах, бүр миний дэргэд нь зогссон тэр модонд хүргэх “давчуу бөгөөд нарийн замыг би харав; мөн түүнчлэн энэ нь урсгалын эхийн дэргэдүүр өнгөрч, дэлхий мэт уужим бөгөөд цэлгэр ^бталбар тийш удирдах ажээ.

21 Мөн би тоогүй олон хүмүүсийг харав, дэргэд нь миний зогссон тэр модны зүг удирдах “замыг олохоор тэднээс олон нь урагш зүтгэж байгааг би харав.

22 Мөнхүү улиран тохиох дор тэд урагшлан мөн модны зүг дагуулах замаар явж эхэлсэн буюу.

23 Мөнхүү улиран тохиох

11б 1 Ниф. 11:8.

12а су Баяр баясгалан.

б Алма 36:24.

в 1 Ниф. 15:36.

13а 1 Ниф. 12:16–18;

15:26–29.

18а 2 Ниф. 5:20–25.

19а Дуул. 2:9; Илч. 12:5;

исо, Илч. 19:15;

1 Ниф. 8:30; 11:25;

15:23–24.

20а Мат. 7:14;

2 Ниф. 31:17–20.

б Мат. 13:38.

21а су Зам.

дор харанхуй “манан бий болов; тийм ээ, бүр харанхуй үлэмжийн их манан, үүний хэрээр харгуйг эхэлсэн тэд замаа алдсанаар тэд хэрэн тэнэж төөрөлдөх ажгуу.

24 Мөнхүү улиран тохиох дор шаргуу урагшлан буй бусдыг би ажив, мөн тэд урагшлан мөн төмөр бариулын үзүүрт хүрэн барив; мөн тэд харанхуй манан дундуур зүтгэн урагшилж, ойртон бүр мөн уг модны “жимснээс тэд хүртэх хүртлээ төмөр бариулаас барьсаар явах ажээ.

25 Мөн тэд уг модны жимснээс хүртсэний дараа тэд “ичингүйрхэв гэлтэй нүд бэлчээн харах ажээ.

26 Мөн түүнчлэн би эргэн тойрон хараа бэлчээн, бас уст голын нөгөө эрэгт агуу хийгээд “нүсэр барилгыг харав; мөн энэ нь газраас өндөрт, агаарт тогтсон мэт байв.

27 Мөн энэ нь өтөл болоод залуу, эрэгтэй болоод эмэгтэй хүмүүсээр дүүрэн байв; мөн тэдний хувцасласан маяг нь үлэмж тансаг; мөн тэд, ирж бас жимснээс хүртсэн тэднийг хуруугаараа занган басхүү “элэглэх байдалтай байх ажээ.

28 Мөн тэд жимсийг “амссныхаа дараа тэднийг тохуурхсан тэднээс ^бичингүйрхсэн болой; мөн тэд хориглогдсон

замаар будилан “орж мөн төөрч байв.

29 Мөн эдүгээ би, Нифай, эцгийнхээ “бүх үгсийг ярих нь үгүй.

30 Гэвч товчлон бичвээс, болгоогтун, замаараа урагш зүтгэж буй бусад олныг тэрээр харав; тэд ирж бас төмөр “бариулын үзүүрт хүрч барив; мөн тэд урагшлан, доош унаад мөн уг модны жимснээс хүртэх хүртэл төмөр бариулаас үргэлж тууштай зуурсаар урагш зүтгэх бөлгөө.

31 Мөн түүнчлэн тэрбээр агуу хийгээд нүсэр барилгыг зүглэн бэдрэх бусад “олныг харсан бөлгөө.

32 Мөнхүү улиран тохиох дор олон нь “урсгалын гүнд живэв; мөн олон нь түүний хараанаас алдран, этгээд замаар бэдрэх бөлгөө.

33 Мөн уг этгээд барилга уруу орогсод үлэмж олон байв. Мөн тэд тэр барилга дотор орсны эцэст түүнчлэн жимснээс хүртэх намайг болон тэднийг хуруугаараа занган “тохуурхацгаах аж; гэвч бид тэднийг анхаарсан нь үгүй болой.

34 Эдгээр нь миний эцгийн үгс буюу: Учир нь тэднийг “анхаарсан болгон нь будилан одох ажгуу.

35 Мөн “Лемен Лемүел хоёр

23a 1 Ниф. 12:17; 15:24.

24a 1 Ниф. 8:10–12.

25a Ром 1:16; 2 Тим. 1:8;
Алма 46:21;
Морм. 8:38.

26a 1 Ниф. 11:35–36;
12:18.

27a су Бардамнал.

28a 2 Петр 2:19–22.

б Марк 4:14–20; 8:38;
Лук 8:11–15;
Иохан 12:42–43.

в су Урвалт.
29a 1 Ниф. 1:16–17.

30a 1 Ниф. 15:23–24.

31a Мат. 7:13.

32a 1 Ниф. 15:26–29.

33a су Хавчих, Хавчлага.

34a Ег. 23:2.

35a 1 Ниф. 8:17–18;

2 Ниф. 5:19–24.

тэр жимснээс хүртсэнгүй хэмээн эцэг минь хэлэв.

36 Мөнхүү улиран тохиох дор миний эцэг өөрийн зүүд буюу үзэгдлийн тухай тэрхүү бүх үгсийг ярьсны эцэст, тэрээр бидэнд хэлэв, үзэгдэлд харсан тэр зүйлүүдийнхээ учир, Лемең Лемүел хоёрын улмаас тэрээр үлэмж айв; тийм ээ, тэднийг Их Эзэний дэргэдээс зайлуулахдаг болуузай хэмээн тэр айсан ажээ.

37 Мөн Их Эзэн тэднийг нигүүлсэн, зайлуулахгүй байж болохын тулд тэднийг өөрийнх нь үгийг дуулахыг, эцэг минь энэрэлт “эцгийн бүхий л сэтгэлээр ухуулж, тийм ээ, эцэг минь тэдэнд номлон байв.

38 Мөн тэрбээр тэдэнд хандан номлосны дараа, мөн түүнчлэн тэдэнд олон зүйлийн тухай бошигლოსны эцэст Их Эзэний зарлигуудыг дага хэмээн тэр тэдэнд тушаав; мөн тэр тэдэнд хандан ярьж байсныгаа зогсов.

БҮЛЭГ 9

Нифай хоёр хэсэг цэдэг бүтээв—Тус бүр нь Нифайн ялтсууд хэмээн нэрлэгдэв—Их ялтсууд нь төрийн түүхийг; бага ялтсууд нь үндсэндээ ариун зүйлүүдийн үйлийг агуулав. Ойролцоогоор мээ 600–592 он.

Мөнхүү эдгээр бүхий л зүйлийг тэрээр Лемүелийн “хөндийд, майханд суурьшин байхдаа миний эцэг харж, бас сонсож, мөн ярьсан бөлгөө, мөн түүнчлэн эдгээр ялтсууд дээр бичигдэж эс чадаж тэр бусад агуу олон зүйлийг буюу.

2 Мөн эдүгээ, би эдгээр ялтсуудын талаар ярьсанчлан, болгоогтун тэдгээр нь миний хүмүүсийн түүхийн бүрэн шастирыг дээр нь хийсэн тэр ялтсууд биш болой; учир нь би өөрийн хүмүүсийн бүрэн түүхийн шастирыг дээр нь хийсэн тэр “ялтсуудад бибээр Нифайн хэмээх нэрийг өгсөн буюу; иймийн тул тэдгээр нь Нифайн ялтсууд хэмээн өөрийн минь нэрээр нэршив, мөн эдгээр ялтсууд түүнчлэн Нифайн ялтсууд хэмээн нэрлэгддэг бөлгөө.

3 Гэсэн хэдий ч, би эдгээр ялтсуудыг өөрийн хүмүүсийн “тохинууллын шастирыг сийлэх онцгой^б зорилгын улмаас бүтээвэл зохино хэмээн Их Эзэнээс зарлиг хүлээн авсан болой би.

4 Нөгөө ялтсууд дээр хаадын засаглал, мөн миний хүмүүсийн дайнууд болон тэмцлийн шастир сийлэгдэх ёстой ажгуу; иймийн тул эдгээр ялтсууд нь тохинууллын тухайд илүүтэй зориулагдах буюу; мөн нөгөө “ялтсууд нь миний хүмүүсийн дайн болон

37a су Гэр бүл; Эцэг эх.
9 1a 1 Ниф. 2:4–6, 8,
14–15; 16:6.
2a 1 Ниф. 19:2, 4;

Иаков 3:13–14;
Мор. үгс 1:2–11;
С ба Г 10:38–40.
су Ялтсууд.

3a 1 Ниф. 6:3.
б С ба Г 3:19.
4a Иаков 1:2–4;
Мор. үгс 1:10.

тэмцэл бас хаадын засаглалыг тухайлахад илүүтэй зориулагдах болой.

5 Иймийн тул, эдгээр ялтсуудыг түүний “мэргэн зорилгын тулд бүтээхийг Их Эзэн надад зарлигласан, миний мэдэх нь үгүй тэрхүү зорилго буюу.

6 Харин Их Эзэн бүх зүйлийг эхлэлээс нь “мэдэх буюу; иймийн тул, тэрээр хүмүүний үрсийн дунд өөрийн бүхий л үйлүүдээ гүйцэлдүүлэх замыг бэлтгэх ажээ; учир нь болгоогтун, тэрбээр өөрийн бүх үгсийг биелэл болгох бүхий л “хүчийг агуулах ажгуу. Мөн энэ нь ийн байх болой. Амен.

БҮЛЭГ 10

Иудейчүүд вавилончуудад боолчлолд аваачигдах болно хэмээн Лихай угтан хэлэв—Тэрээр нэгэн Аврагч, Гэтэлгэгч, Мессиа иудейчүүдийн дунд ирэхийг хэлэв—Лихай түүнчлэн Бурханы Хурганд баптисм хүртээх тэр нэгний ирэлтийн тухай хэлэв—Мессиагийн үхэл болон амилалтыг Лихай хэлэв—Тэрээр Израилын тараагдалт болон цугларалтыг чидуны модтой зүйрлэв—Нифай Бурханы Хүүгийн тухай, Ариун Сүнсний

бэлгийн тухай болон зөв шударга байх хэрэгцээний тухай ярих. Ойролцоогоор мээ 600–592 он.

Мөн эдүгээ би, Нифай, эдгээр “ялтсууд дээр өөрийн явдал хэргийн тухай, мөн өөрийн засаглал болон тохиноуллын тухай шастирыг үйлдэхээр зорих буюу, иймийн тул, өөрийн шастирыг үргэлжлүүлэхийн тулд би эцгийнхээ тухай зүйлүүдийн заримыг, мөн түүнчлэн ах нарынхаа тухай ярих ёстой бөлгөө.

2 Учир нь болгоогтун, мөнхүү улиран тохиох дор миний эцэг өөрийн яриаг “зүүднийхээ тухай үгсээр, мөн түүнчлэн тэднийг бүхий л хүчээрээ чармайхыг ухуулан дуусгавар болгосны дараа, тэрээр тэдэнд хандан иудейчүүдийн талаар ярих—

3 Үүнчлэн тэд мөн бүр агуу хот “Иерусалим устгагдсаны дараа, мөн олон нь “олзлогдон “Вавилонд хүргэгдэж, Их Эзэнээс тогтоосон тэр цаг нь ирэхээр, тэд дахин ‘буцах бөлгөө, тийм ээ, бүр боолчлолоос гарч буцаан авчрагдах бөлгөө; мөн тэд боолчлолоос буцаж ирсний эцэст тэд өвийн нутгаа дахин эзэмших болой.

5а 1 Ниф. 19:3;
Мор. үгс 1:7;
Алма 37:2, 12, 14.

6а 2 Ниф. 9:20;
С ба Г 38:2;
Моисе 1:6, 35.
су Бүхнийг Мэдэгч.
б Мат. 28:18.

10 1а 1 Ниф. 9:1–5;
19:1–6;
Иаков 1:1–4.

2а 1 Ниф. 8.
3а Ест. 2:6;
2 Ниф. 6:8;
Хил. 8:20–21.
б 2 Ниф. 25:10.

су Он дараалал—
587 мээ.
в Езек. 24:2;
1 Ниф. 1:13;
Омнаи 1:15.
г Иер. 29:10;
2 Ниф. 6:8–9.

4 Тийм ээ, бүр миний эцэг Иерусалимыг орхисон цагаас “зургаан зуун жилийн хойно, Их Эзэн Бурхан иудейчүүдийн дунд нэгэн “бошиглогчийг төрүүлэх болно—бүр нэгэн “Мессиаг, эсвээс, өөр үгээр, дэлхийн нэгэн Аврагчийг.

5 Мөн түүнчлэн тэрбээр бошиглогчдын талаар ярьсан бөлгөө, түүний тухайлан ярьсан тэрхүү Мессиагийн, эсвээс дэлхийн Гэтэлгэгчийн талаар “гэрчилсэн тэд хичнээн олон тоотой билээ!

6 Иймийн тул, бүх хүмүүн төөрөлдсөн бас “унасан байдалд ордог буюу, тэд энэхүү Гэтэлгэгчид тулгуурлахгүй бөгөөс үргэлжид тийм байх бөлгөө.

7 Мөн түүнчлэн тэрээр Их Эзэний замыг бэлтгэхээр, Мессиагийн өмнө ирэх нэгэн “бошиглогчийн талаар өгүүлсэн ажгуу.

8 Тийм ээ, бүр тэрээр урагшлан мөн аглаг буйдад: Та нар Их Эзэний замыг “бэлтгэцгээ, мөн түүний харгуйг шулуутга; учир нь та нарын эс мэдэх нэгэн дунд чинь зогсох бөлгөө; басхүү тэрээр надаас илүү хүчтэй, түүний шаахайн үдээсийг тайлах зохистой нь би биш хэмээн хашгирах бөлгөө. Мөн миний

эцэг энэ зүйлийн талаар ихийг өгүүлсэн буюу.

9 Мөн Иорданы цаад талд “Бетабарад тэр баптисм хүртээх ёстой хэмээн миний эцэг хэлэв; мөн түүнчлэн тэрээр “баптисм хүртээх болно; бүр тэрээр Мессиад баптисм хүртээх болно хэмээн тэр хэлэв.

10 Мөн тэр Мессиад баптисм хүртээсний дараа, тэрээр бүх дэлхийн нүглийг үүрэх ёстой түүнийг, Бурханы “Хурганд баптисм хүртээснээ гэрчлэн мөн нотлон өгүүлэх болно.

11 Мөнхүү улиран тохиох дор эцэг минь эдгээр үгсийг ярьсныхаа дараа миний ах нарт хандан тэрээр иудейчүүдийн дунд номлогдох сайн мэдээний талаар, мөн түүнчлэн Иудейчүүдийн “итгэлгүйдээ “бууран доройтох талаар ярьсан бөлгөө. Мөн тэр ирэх ёстой Мессиаг тэд “алсны дараа, мөн тэрээр алагдсаныхаа дараа тэр үхлээс “босох болно, мөн “Ариун Сүнсээр өөрийгөө харийнханд үзүүлэх болно.

12 Тийм ээ, түүгээр үл барам эцэг минь ихийг өгүүлсэн билээ, харийнханы талаар, мөн түүнчлэн Израилын угсааны талаар, мөчрүүд нь хугаран бүх дэлхийн гадаргуугаар

4а 1 Ниф. 19:8;

2 Ниф. 25:19;

3 Ниф. 1:1.

б 1 Ниф. 22:20–21.

в су Мессиа.

5а Иаков 7:11;

Мозая 13:33;

Хил. 8:19–24;

3 Ниф. 20:23–24.

6а су Адам Ева хоёрын Уналт.

7а 1 Ниф. 11:27;

2 Ниф. 31:4.

8а Иса. 40:3;

Мат. 3:1–3.

9а Иохан 1:28.

б су Иохан Баптист.

10а су Бурханы Хурга.

11а Морм. 5:14.

б Иаков 4:14–18.

в су Есүс Христ;

Цовдуулалт.

г су Амилуулалт.

д су Ариун Сүнс.

“тараагдах тэр, ^бчидуны модтой адилтгам байх буюу хэмээв.

13 Иймийн тул, тэрээр бид бүх дэлхийн гадаргуугаар тараагдах болно хэмээсэн Их Эзэний үг гүйцэлдэхийн тулд бид амлалтын “нутгийн зүг нэгэн зорилготойгоор удирдагдах нь гарцаагүйг хэлсэн ажгуу.

14 Мөн Израилын угсаа тараагдсаны дараа дахин хамтдаа нэгдэн “цуглуулагдана; өөрөөр хэлбэл чухамдаа ^бхарийнхан Бурханы Сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авсны дараа, ^бчидуны модны унаган мөчрүүд буюу Израилын угсаанаас үлдэгсэд нь үүнд залгагдах болно, өөрөөр хэлбэл үнэн Мессиагийн, Их Эзэнийхээ болон Гэтэлгэгчийнхээ мэдлэгт орох болно.

15 Мөн миний эцэг ийм маягийн хэлээр ах нарт маань хандан ярьж бас бошиглосон бөлгөө, мөн түүнчлэн миний энэ номонд эс бичиглэх өөр олон зүйлийг; учир нь бибээр тэдгээрээс минийхээр зүйд нийцэх болгоныг нь өөрийн “нөгөө номонд бичиглэсэн бөлгөө.

16 Мөн миний тухайлан

өгүүлсэн эдгээр бүхий л зүйлийг эцэг минь Лемуелийн хөндийд майханд аж төрөн байхдаа үйлдэв.

17 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, эцгийнхээ бүх “үгсийг, түүний ^бүзэгдэлд харсан тэдгээр зүйлүүдийн талаар, мөн түүнчлэн тэрбээр Бурханы Хүүд итгэлтэй байснаар хүлээн авсан тэрхүү хүч болох Ариун Сүнсний хүчээр түүний ярьсан тэдгээр зүйлийг сонссоны дараа — мөн Бурханы Хүү нь тэрхүү ирэх ёстой ^бМессиа байсан бөлгөө— ‘хуучин цагийн адилаар, хүмүүний үрсэд тэрээр өөрийгөө харуулах тэр цагт ч түүнийг ^дхичээнгүйлэн хайгч хэн бүхэнд Бурханы “бэлэг болох Ариун Сүнсний хүчээр эдгээр зүйлсийг би, Нифай, түүнчлэн өөрөө харж бас сонсож, түүнчлэн мэдэхийг хүсч байлаа.

18 Учир нь тэр өчигдөр, өнөөдөр бас үргэлжид “адил байх буюу; мөн хэрэв тэд тэрчлэн наманчилж мөн түүнд ирвээс, бүх хүмүүнд энэ дэлхийн үүслээс зам бэлтгэгдсэн байдаг бөлгөө.

19 Учир нь хичээнгүйлэн хайгч тэр олох болно; мөн Бурханы “нууцууд нь тэдэнд

12a 1 Ниф. 22:3–8.

су Израил—
Израилын
тараагдалт.

б Эхл. 49:22–26;

1 Ниф. 15:12;

2 Ниф. 3:4–5;

Иаков 5; 6:1–7.

су Чидуны мод; Их

Эзэний талбай.

13a 1 Ниф. 2:20.

су Амлалтын нутаг.

14a су Израил—Израилын
цугларалт.

б 1 Ниф. 13:42;

С ба Г 14:10.

в Иаков 5:8, 52, 54,

60, 68.

15a 1 Ниф. 1:16–17.

17a Инос 1:3;

Алма 36:17.

б 1 Ниф. 8:2.

в су Мессиа.

г С ба Г 20:26.

д Моро. 10:4–5, 7, 19.

е су Ариун Сүнс.

18a Евр. 13:8;

Морм. 9:9;

С ба Г 20:12.

су Бурхан, Бурхан

тэргүүтэн.

19a су Бурханы

нууцууд.

энэ цагт ч хуучин цагийн адил, мөн ирэх цагийн адилаар хуучин цагт ч ^аАриун Сүнсний хүчээр задлагдах ажгуу; иймийн тул, Их Эзэний ^бзамнал нэгэн мөнхийн эргэлт авай.

20 Тиймийн тул сана, ай хүмүүн та нар, өөрийн бүхий л үйлийнхээ тул та нар ^ашүүлтэнд хүргэгдэх бөлгөө.

21 Иймийн тул, хэрэв та нар ^асорилтынхоо өдрүүдэд ёсон бусыг үйлдэхийг эрэлхийлсэн аваас, тэгвэл та нар Бурханы шүүлтийн суудлын өмнө ^бцэвэр бус нь тогтоогдоно; мөн цэвэр бус нэгээхэн ч зүйл Бурхантай хамт оршиж эс чадна; иймийн тул, та нар үүрд хаягдах ёстой болно.

22 Мөн эдгээр зүйлсийг ярих эрх мэдлийг Ариун Сүнс надад өгсөн бөлгөө, мөн тэдгээрийг үгүйсгэх нь үгүй.

БҮЛЭГ 11

Нифай Их Эзэний Сүнсийг харж мөн амьдралын мод үзэгдэлд харуулагдав — Тэрбээр Бурханы Хүүгийн эхийг харж мөн Бурханы хүлцлийн тухай олж мэдэв — Бурханы Хурганы баптисмыг, тохинууллыг мөн цовдлолтыг нь тэрбээр харав — Тэрбээр түүнчлэн Хурганы Арванхоёр

Төлөөлөгчийн дуудлага болон тохинууллыг харав. Ойролцоогоор мээ 600–592 он.

Учир нь улиран тохиох дор би эцгийнхээ үзсэн тэр зүйлийг мэдэхийг хүссэний дараа, мөн Их Эзэн тэдгээрийг надад мэдүүлж болно хэмээн итгэсээр авай, би ийн дотроо ^атунгаан суух зуур би Их Эзэний Сүнсэнд ^бавтагдан алсад одож, тийм ээ, миний урьд өмнө нь хэзээ ч хараагүй, мөн миний хэзээ ч урьд нь хөл тавьж байгаагүй үлэмж өндөр ^вууланд гарлаа.

2 Мөн Сүнс надад хандан: Болгоогтун, юуг хүснэв та? хэмээв.

3 Мөн би: Эцгийнхээ ^аүзсэн тэр зүйлийг би харах хүсэлтэй гэв.

4 Мөн Сүнс надад хандан: Эцгийнхээ өгүүлсэн тэрхүү ^амодыг тэрээр харсан хэмээн та итгэнэ үү?

5 Мөн би хэлэв: Тийм ээ, эцгийнхээ бүх үгсэд миний ^аитгэдгийг та мэдэх буйза.

6 Мөн би эдгээр үгсийг ярихад Сүнс өндөр дуугаар хашгирч, өгүүлсэн нь: Бүхний дээд Бурхан Их Эзэнд Хосанна; учир нь тэр бүх ^адэлхийн Бурхан, тийм ээ, бүр бүхнээс дээгүүр ажгуу. Мөн адислагдсан болой та, Нифай, бүхний

19б су Ариун Сүнс.
в Алма 7:20;

С ба Г 3:2; 35:1.

20а Ном. үгс 12:14;

2 Ниф. 9:46.

су Эцсийн шүүлт.

21а Алма 34:32–35.

б 1 Кор. 6:9–10;

3 Ниф. 27:19;

С ба Г 76:50–62;

Моисе 6:57.

11 1а С ба Г 76:19.

су Тунгаан бодох.

б 2 Кор. 12:1–4;

Илч. 21:10;

2 Ниф. 4:25;

Моисе 1:1.

в Дэд хууль 10:1;

Ифер 3:1.

3а 1 Ниф. 8:2–34.

4а 1 Ниф. 8:10–12;

15:21–22.

5а 1 Ниф. 2:16.

6а Ег. 9:29;

2 Ниф. 29:7;

3 Ниф. 11:14;

Моисе 6:44.

дээд Бурханы Хүүд та ^битгэд-
гийн учир бөлгөө; иймийн
тул та хүссэн зүйлүүдээ харах
болно.

7 Мөн болгоогтун энэ зүйл
“тэмдгээр танд өгөгдөх бол-
но, эцгийн тань амссан тэр
жимсийг өгөгч модыг та харс-
ны дараа, та түүнчлэн тэнгэр-
рээс доошлон буух хүнийг
ажин, мөн та түүнийг гэрчлэх
болно; мөн та түүнийг гэр-
чилснийхээ дараа энэ бол
Бурханы Хүү юм гэдгийг та
^бнотлон өгүүлэх болно.

8 Мөнхүү улиран тохиох дор
Сүнс надад хандан: Харагтун!
хэмээв. Мөн би харвал модыг
ажив; мөн энэ нь миний эц-
гийн үзсэн “модтой эгээ адил
байсан бөлгөө; мөн үүний
үзэсгэлэн нь нэвт, тийм ээ,
бүх үзэсгэлэнтээс үлэмж; мөн
түүний ^бцайрах нь будрах
цасны цайрахаас ч үлэмж
бөлгөө.

9 Мөнхүү улиран тохиох дор
би модыг хараад, Сүнсэнд
хандан: Та надад бүхнээс “эр-
хэм дээд тэр модыг үзүүлс-
нийг би ухаарав хэмээн хэлэв.

10 Мөн тэрээр надад: Юуг
хүснэв та? хэмээв.

11 Мөн би түүнд хандаж:
Түүний “чухам юу өгүүлж буйг
мэдэхийг хүснэм хэмээв —
учир нь би түүнтэй хүнтэй
ярихын адилаар ярив; учир
нь, тэрээр хүмүүний ^бхэлбэр-
тэй байсныг би ажигласан;

тийм хэдий ч, тэр Их Эзэний
Сүнс байсныг би мэдсэн бөл-
гөө; мөн тэр надад хандан
нэг хүн нөгөөтэйгөө ярихын
адил ярьсан буюу.

12 Мөнхүү улиран тохиох
дор тэр надад хандан: Хараг-
тун! хэмээв. Мөн би түүний
зүг харвал, мөн би түүнийг
үзсэнгүй; учир нь тэрээр ми-
ний дэргэдээс холдон одсон
байлаа.

13 Мөнхүү улиран тохиох
дор би харж басхүү их хот
Иерусалимыг, мөн түүнчлэн
бусад хотуудыг үзэв. Мөн би
Назар хотыг үзэв; бас “Назар
хот дахь ^бонгон бүсгүйг би
харав, мөн тэрбээр үлэмж
хонгор мөн цагаан байлаа.

14 Мөнхүү улиран тохиох
дор “тэнгэр нээгдэхийг үзэв
би; мөн тэнгэр элч доош
бууж мөн миний өмнө зогсов;
мөн тэрээр надад хандан: Ни-
фай, юуг харнав та? хэмээв.

15 Мөн би түүнд хандан:
Онгон бүсгүйг, бусад бүх
онгон бүсгүйчүүдээс илүү
хамгийн үзэсгэлэн гоо бас
хонгорхон түүнийг, хэмээв.

16 Мөн тэр надад хандан:
Бурханы хүлцлийг мэдэх үү
та? хэмээв.

17 Мөн би түүнд хандан:
Тэрбээр хүүхдүүддээ хайр-
тайг нь мэднэ би; тийм бо-
ловч, бүх зүйлүүдийн утгыг
мэдэх нь үгүй би хэмээв.

18 Мөн тэр надад хандан:

6б су Итгэлтэй байх,
Итгэл.

7а су Тэмдэг.

б су Гэрчлэл.

8а 1 Ниф. 8:10.

б 1 Ниф. 8:11.

9а 1 Ниф. 11:22–25.

11а Эхл. 40:8.

б Ифер 3:15–16.

13а Мат. 2:23.

б Лук 1:26–27;

Алма 7:10.

су Мариа, Есүсийн
эх.

14а Езек. 1:1; 1 Ниф. 1:8.

Болгоогтун, таны харж буй тэр “онгон бүсгүй бол Бурханы Хүүгийн махан бодийн биеийг төрүүлэгч”^б эх нь бөлгөө хэмээв.

19 Мөнхүү улиран тохиох дор тэр бүсгүйг Сүнс авч одохыг би харав; мөн “Сүнс бүсгүйг авч одсоны дараа хэсэг байзнаад тэнгэр элч надад хандан: Харагтун! хэмээв.

20 Мөн би сайхь онгон бүсгүйг дахин харж, гар дээрээ “хүүхэд тэвэрсэн байхыг болгоов.

21 Мөн тэнгэр элч надад хандан: Бурханы “Хургыг, тийм ээ, бүр Мөнхийн”^б Эцэгийн “Хүүг болгоогтун! Эцгийнхээ харсан тэр ‘мод ямар утгатайг мэдэв үү, та? хэмээв.

22 Мөн би түүнд хариулж, өгүүлсэн нь: Тийм ээ, энэ бол хүмүүний үрсийн зүрхэнд хааяагүй түгэх Бурханы “хайр; иймийн тул, энэ нь бүхнээс илүү, хамгийн ихээр хүслийг татагч буюу.

23 Мөн тэрээр надад хандан ярьж, өгүүдрүүн: Тийм ээ, мөн бодгальд хамгийн их “баясгалант болой.

24 Мөн тэрээр эдгээр үгсийг ярьсныхаа дараа, тэрбээр надад хандан: Харагтун! хэмээв. Мөн би харвал, тийнхүү

Бурханы Хүү хүмүүний үрсийн дунд “явж байхыг би ажиглав; мөн олон нь түүний хөлд унан бас түүнийг бишрэхийг үзэв би.

25 Мөнхүү улиран тохиох дор миний эцгийн үзсэн тэр төмөр “барил нь Бурханы үг байсныг би мэдэв; тэр нь “амьдралын усан оргилуур уруу эсвээс амьдралын “мод уруу удирдах ажгуу; тэр ус нь Бурханы хайрын бэлэгдэл ажгуу; мөн түүнчлэн уг мод Бурханы хайрыг илтгэж буйг би ухаарав.

26 Мөн тэнгэр элч надад дахин хандаж: Харагтун мөн Бурханы “хүлцлийг болгоогтун! хэмээв.

27 Мөн би харж бас эцгийнхээ ярьсан дэлхийн Гэтэлгэгчийг “болгоов; мөн түүнчлэн түүний өмнө замыг нь бэлтгэх нэгэн “бошиглогчийг би болгоов. Мөн Бурханы Хурга урагш явж түүгээр “баптисм хүртэв; мөн тэрбээр баптисм хүртсэний дараа, тэнгэр нээгдэж мөн Ариун Сүнс тэнгэрээс “тагтаа хэлбэртэйгээр бууж мөн түүн дээр тогтнохыг би болгоов.

28 Мөн тэрээр хүмүүст их “хүч бас агуу их алдар суугаар тохиуулж урагшлан явахыг

18a Иса. 7:14;
Лук 1:34–35.
б Мозая 3:8.

19a Мат. 1:20.

20a Лук 2:16.

21a су Бурханы Хурга.
б су Бурхан, Бурхан тэргүүтэн — Эцэг Бурхан.
в су Есүс Христ.

г 1 Ниф. 8:10;
Алма 5:62.
су Амьдралын мод.

22a су Хайр.

23a су Баяр баясгалан.

24a Лук 4:14–21.

25a 1 Ниф. 8:19.

б су Амьдралын ус.

в Эхл. 2:9;
Алма 32:40–41;

Моце 4:28, 31.
26a 1 Ниф. 11:16–33.
27a 2 Ниф. 25:13.

б Мат. 11:10;

1 Ниф. 10:7–10;

2 Ниф. 31:4.

в су Баптисм,
Баптисм хүртээх.

г су Тагтааны тэмдэг.
28a С ба Г 138:25–26.

би болгоов; мөн ард олон түүнийг сонсохоор нэгдэн цугларч байв; мөн тэд түүнийг өөрсдийн дундаас зайлуулан хөөснийг би ажиглав.

29 Мөн түүнчлэн түүнийг дагалдах бусад “арванхоёрыг би болгоов. Мөнхүү улиран тохиох дор Сүнс тэднийг миний өмнөөс авч одов, мөн би тэднийг харсан нь үгүй.

30 Мөнхүү улиран тохиох дор тэнгэр элч надад хандан дахин ярьж өгүүлсэн нь: Харагтун! Мөн би харав, мөн тэнгэр дахин нээгдэхийг би болгоов, мөн “тэнгэр элчүүд хүмүүний үрсийн дээр хүрэлцэн ирэхийг би үзэв; мөн тэд тэдэнд тохинуулсан бөлгөө.

31 Мөн тэрээр дахин надад хандаж, хэлрүүн: Харагтун! хэмээв. Мөн би харав, бас Бурханы Хурга хүмүүний үрсийн дунд урагшлан явахыг би болгоов. Мөн өвчилсөн, бас олон зүйл өвчний улмаас, мөн “чөтгөрүүд болон ^ббузар сүнстэйн улмаас зовж шаналсан олныг би болгоов; мөнхүү тэнгэр элч ярьж, бас эдгээр бүх зүйлийг надад үзүүлсэн авай. Мөн тэд Бурханы Хурганы хүчээр ^аэдгээгдэв; мөн чөтгөрүүд болон бузар сүнснүүд зайлуулагдав.

32 Мөнхүү улиран тохиох дор сайхь тэнгэр элч надад хандан дахин ярьж, хэлсэн

нь: Харагтун! Мөн би харж бас Бурханы Хургыг, тэрээр хүмүүст баригдсаныг нь болгоов; тийм ээ, Үүрдийн Бурханы Хүү дэлхийнхээр “шүүгдэв; мөн би харсан бөгөөд бас гэрчлэх буюу.

33 Мөн би, Нифай, тэрбээр энэ дэлхийн нүглүүдийн тул “загалмайд өргөгдөн мөн ^балагдсаныг үзсэн бөлгөө.

34 Мөн түүнийг алагдсаны дараа би газар дэлхийн олныг, Их Эзэний тэнгэр элчээр Хурганы төлөөлөгч хэмээн нэрлэгдсэн арванхоёрын эсрэг тэмцэхээр тэд хамтран цугларсныг үзэв.

35 Мөн газар дэлхийн олон нь хамтран цугларав; мөн тэд миний эцгийн үзсэн барилгын адил том бөгөөд “нүсэр байшинд байсныг би үзэв. Мөн Их Эзэний тэнгэр элч надад хандан дахин ярьж, хэлрүүн: Дэлхий болон түүний мэргэн ухааныг болгоогтун; тийм ээ, Израилын угсаа Хурганы арванхоёр төлөөлөгчийн эсрэг тэмцэхээр хамтран цугларсныг болгоогтун.

36 Мөнхүү улиран тохиох дор тэр агуу хийгээд нүсэр барилга нь дэлхийн “бардамнал байсныг би үзсэн бас гэрчилнэ; мөн энэ нь унав, мөн түүний уналт үлэмж аймшигтай буюу. Мөн Их Эзэний тэнгэр элч дахин надад

29a су Төлөөлөгч.

30a су Тэнгэр элчүүд.

31a Марк 5:15–20;

Мозая 3:5–7.

су Чөтгөр.

б су Сүнс—Муу ёрын

сүнснүүд.

в су Эдгээх, Эдгэрэх.

32a Марк 15:17–20.

33a Иохан 19:16–19;

Мозая 3:9–10;

3 Ниф. 27:14.

су Загалмай.

б су Цагаатгах,

Цагаатгал.

35a 1 Ниф. 8:26; 12:18.

36a су Бардамнал.

хандан ярьж хэлрүүн: Хурганы арванхоёр төлөөлөгчийн эсрэг тэмцэх бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүсийн устгал ийн тохиох ажгуу.

БҮЛЭГ 12

Нифай амлалтын нутгийг; үүний оршин суугчдын зөв шударга байдал, алдас, мөн буурах уналтыг; Бурханы Хурганы тэдний дундах айлчлалыг; Арванхоёр шавь бас Арванхоёр Төлөөлөгч Израилыг хэрхэн шүүхийг; мөн итгэлгүйдээ бууран доройтсон тэдний жигшим болоод бузар байдлыг үзэгдэлд харав. Ойролцоогоор мээ 600–592 он.

Мөнхүү улиран тохиох дор сайхь тэнгэр элч надад хандан: Хар, мөн үр удмаа, мөн түүнчлэн ах нарынхаа удмыг болгоогтун хэмээв. Мөн би харваас, амлалтын “нутгийг болгоов; мөн би цугласан олон хүмүүсийг ажиглав, тийм ээ, бүр тоогоороо тэнгисийн элсний ширхэг лугаа адил тийм олон байсан ажгуу.

2 Мөнхүү улиран тохиох дор нэг нэгнийхээ эсрэг тулалдахаар бөөгнөрөн цугларсан олныг би болгоов; мөн “дайнүүд, мөн дайны цуурхлууд, мөн миний хүмүүсийн дундаас илдэнд эрсдэх асар олныг би олж харав.

3 Мөнхүү улиран тохиох

дор олон үе, тэр нутагт дайн тулаанууд мөн хэрүүл тэмцлийн дунд улиран өнгөрөхийг би ажиглав; мөн олон хот, тийм ээ, бүр миний бие тоолшгүй тийм олон тэднийг бибээр олж харав.

4 Мөнхүү улиран тохиох дор амлалтын нутгийн гадаргуу дахь “харанхуй” мананг би үзэв; мөн би цахилгаан гялбахыг харав, бас тэнгэр дуугаран мөн газар хөдлөх, бас олон янзын нүргээнт чимээг би сонсов; мөн газар болон хад чулууг, тэдгээр нь хагаран цуурахыг би үзэв; мөн уулс хэдэн хэсэг болон нурж унахыг би харав; мөн би тал газруудыг, тэдгээр нь анцав гаран эвдрэхийг би үзэв; мөн би олон хот, тэдгээр нь “живүүлэгдсэнийг харав; мөн түймэрт шатаагдсан тэдгээр олныг би үзэв; мөн доргин хөдлөхийн учир, хөсөр унах олныг би үзэв.

5 Мөнхүү улиран тохиох дор эдгээр зүйлийг үзсэний дараа би харанхуйлах “мананг, энэ нь газрын гадаргуугаас арилан одохыг би үзэв; мөн болгоогтун, Их Эзэний агуу хийгээд аймшигт шүүлтийн учир унаагүй олон хүнийг би үзэв.

6 Мөн тэнгэр нээгдэж Бурханы “Хурга тэнгэрээс бууж ирэхийг би үзэв; мөн тэрбээр бууж ирээд басхүү тэдэнд өөрийгөө үзүүлсэн бөлгөө.

12 1а су Амлалтын нутаг.
2а Инос 1:24;
Морм. 8:7–8.

су Дайн.
4а 1 Ниф. 19:10.
б Хил. 14:20–28.
в 3 Ниф. 8:14.

5а 3 Ниф. 8:20; 10:9.
6а 2 Ниф. 26:1, 9;
3 Ниф. 11:3–17.

7 Мөн би Ариун Сүнс бусад “арванхоёр дээр бууж ирэхийг түүнчлэн үзэж, басхүү гэрчлэв; мөн тэд Бурханаас томилогдсон хийгээд сонгогдсон бөлгөө.

8 Мөн сайхь тэнгэр элч надад хандан ярьж, хэлсэн нь: Таны үр удамд тохинуулахаар сонгогдсон Хурганы арванхоёр шавийг болгоогтун хэмээв.

9 Мөн тэрбээр надад: Та Хурганы “арванхоёр төлөөлөгчийг санаж байна уу? Болгоогтун, тэд бол Израилын арванхоёр овгийг ^бшүүх тэдгээр бөлгөө; иймийн тул, таны үр удмын арванхоёр тохинуулагч нь тэднээр шүүгдэх болно; та бүгд Израилын угсааных учраас болой.

10 Мөн таны болгоож буй эдгээр “арванхоёр тохинуулагч нь таны үр удмыг шүүх болно. Мөн болгоогтун, тэд үүрд зөв шударга бөлгөө; учир юун хэмээвээс Бурханы Хурганд итгэх тэдний итгэлийн учир тэдний ^бөмсгөл түүний цусанд цагаан болгогдсон бөлгөө.

11 Мөн сайхь тэнгэр элч надад хандан: Харагтун! хэмээв. Мөн би харж, бас “гурван үе зөв шударгаар улиран өнгөрөхийг болгоов; мөн

тэдний өмсгөл бүр Бурханы Хурганыхтай адилтгам цагаан байсан болой. Мөн сайхь тэнгэр элч надад хандан: Тэд түүнд итгэлтэйн учир, эдгээр нь Хурганы цусанд цагаан болгогджээ хэмээв.

12 Мөн би, Нифай, түүнчлэн “дөрөв дэх үеэс олонх нь зөв шударга байдалд улиран өнгөрөхийг харсан бөлгөө.

13 Мөнхүү улиран тохиох дор газар дэлхийн олон түмэн хамтран цуглахыг би харав.

14 Мөн сайхь тэнгэр элч надад: өөрийн үр удмыг, мөн түүнчлэн ах нарынхаа үр удмыг болгоогтун хэмээв.

15 Мөнхүү улиран тохиох дор би харж бас миний үр удам олон олноороо ах нарын маань үр удмын “эсрэг хамтран цугларсан байхыг болгоов; мөн тэд тулалдахаар нэг дор цугларчээ.

16 Мөн сайхь тэнгэр элч надад хандан, өгүүлсэн нь: Эцгийнхээ үзсэн тэр “буртаглагдсан усны эхийг болгоогтун; тийм ээ, бүр түүний тухайлан ярьсан тэр ^бголыг; мөн түүний гүн нь “тамын ёроол бөлгөө.

17 Мөн харанхуйлах “манан нь чөтгөрийн уруу таталт, тэр нь хүмүүний үрсийн мэлмийг ^бсохолж зүрхийг хатууруулж,

7a 3 Ниф. 12:1; 19:12–13.

9a Лук 6:13.

б Мат. 19:28;

С ба Г 29:12.

су Эцсийн шүүлт.

10a 3 Ниф. 27:27;

Морм. 3:18–19.

б Илч. 7:14;

Алма 5:21–27;

13:11–13;

3 Ниф. 27:19–20.

11a 2 Ниф. 26:9–10;

3 Ниф. 27:30–32.

12a Алма 45:10–12;

Хил. 13:5, 9–10;

3 Ниф. 27:32;

4 Ниф. 1:14–27.

15a Морм. 6.

16a су Бузар, Бузар
явдал.

б 1 Ниф. 8:13; 15:26–29.

в су Там.

17a 1 Ниф. 8:23; 15:24;

С ба Г 10:20–32.

б су Урвалт.

мөн “өргөн замаар тэднийг удирдан, чингээд тэд мөхөж, төөрөлдөх бөлгөө.

18 Мөн таны эцгийн харсан тэр агуу хийгээд нүсэр “барилга нь хүмүүний үрсийн хоосон “төсөөлөл болоод “бардамнал болой. Мөн асар том бөгөөд аймшигтай ‘ангал тэднийг тусгаарлах бөлгөө; тийм ээ, бүр Мөнхийн Бурханы, энэ дэлхийн эхлэлээс эдүгээг хүртэл, мөн энэ цаг үеэс хойшид мөн үүрд Ариун Сүнсний гэрчлэх Бурханы Хурга болон Мессиагийн “шударга ёсны үг бөлгөө хэмээв.

19 Мөн тэнгэр элч эдгээр үгсийг ярих зуур, би харж мөн ах нарын маань үр удам тэнгэр элчийн хэлсэнчлэн миний үр удмынхны эсрэг тэмцэхийг үзэв; мөн миний үр удмын бардам зан, мөн чөтгөрийн “уруу таталтын улмаас ах нарын маань үр удам миний үр удмыг “давамгайлахыг би ажиглав.

20 Мөнхүү улиран тохиох дор би харж ах нарын маань үр удмын хүмүүс миний үр удмыг ялсан байхыг болгоов; мөн тэд хэсэг бүлгээрээ нутгийн гадаргуугаар урагшлан явж байсан бөлгөө.

21 Мөн тэд хэсэг бүлгээрээ нэгдэн цугларахыг би үзэв; мөн би тэдний дундах “дайн тулаан болон дайны цуурх-

луудыг үзэв; мөн дайн тулаан болон дайны цуурхлын дунд олон үе улиран өнгөрөхийг би харав.

22 Мөн уг тэнгэр элч надад хандан: Болгоогтун, эдгээр нь итгэлгүйдээ “бууран доройтох болно хэмээв.

23 Мөнхүү улиран тохиох дор тэд итгэлгүйдээ бууран доройтсоны дараа тэд “харанхуй бас зэвүүцэм, басхүү “буртаглагдсан хүмүүс болж, “залхаг хийгээд зүйл бүрийн жигшүүрт үйлээр дүүрснийг харсан бөлгөө.

БҮЛЭГ 13

Харийнханы дунд чөтгөрийн сүм байгуулагдахыг, Америкийг нээж бас түрэмгийлэн эзлэхийг, Библийн судраас олон тодорхой хийгээд эрхэм үнэт хэсгүүд нь алдагдахыг, үүний дүнд харийнханы урвалт гарахыг, сайн мэдээний сэргээлтийг, хожмын үеийн судар гарч ирэхийг, мөн Сион сүндэрлэн баригдахыг Нифай үзэгдэлд харав. Ойролцоогоор мээ 600–592 он.

Мөнхүү улиран тохиох дор тэнгэр элч надад ярьж, хэлрүүн: Харагтун! Мөн би харж бас олон үндэстэн болон хаант гүрнүүдийг болгоов.

2 Мөн сайхь тэнгэр элч надад: Юуг болгооно в та?

17в Мат. 7:13–14.

18а 1 Ниф. 8:26; 11:35–36.

б Иер. 7:24.

в су Бардамнал.

г Лук 16:26;

1 Ниф. 15:28–30.

д су Шударга ёс.

19а су Уруу татах, Уруу таталт.

б Жером 1:10;

Мор. үгс 1:1–2.

21а Морм. 8:8;

Моро. 1:2.

су Дайн.

22а 1 Ниф. 15:13;

2 Ниф. 26:15.

23а 2 Ниф. 26:33.

б 2 Ниф. 5:20–25.

в су Залхуу,

Залхуурах.

хэмээв. Мөн би: Миний бие олон үндэстэн болоод хаант улсуудыг болгооно хэмээв.

3 Мөн тэрээр надад хандан: Эдгээр нь харийнханы үндэстнүүд болон хаант улсууд бөлгөө хэмээв.

4 Мөнхүү улиран тохиох дор би “харийнханы үндэстнүүдийн дунд ⁶агуу сүмийн үүслийг харав.

5 Мөн сайхь тэнгэр элч надад хандан: Бусад бүх сүмүүдээс хамгийн жигшүүрт, Бурханы гэгээнтнүүдийг “хороогч, тийм ээ, тэднийг тарчилгаж бас тэднийг буулгалан, мөн төмөр ⁶буулганд тэднийг хөллөн, мөн тэднийг боолчлолд хүргэгч тэрхүү сүмийн үүслийг болгоогтун хэмээв.

6 Мөнхүү улиран тохиох дор би энэхүү “агуу хийгээд жигшүүрт сүмийг болгоов; мөн үүнийг үүсгэгч нь ⁶чөтгөр байсныг би харав.

7 Мөн түүнчлэн би “алт, бас мөнгө, бас торго, бас гал улаан нөмрөг, бас нарийн нэхээст эд, бас бүх төрлийн тансаг хувцсыг би харав; мөн олон янхан эмсийг би харсан бөлгөө.

8 Мөн сайхь тэнгэр элч надад хандан ярьж, өгүүлсэн нь: Алтыг, бас мөнгийг, торгыг, гал улаан нөмрөгийг, бас нарийн нэхээст эдийг, тансаг

хувцсыг, бас янхан эмсийг болгоогтун, эдгээр нь энэ агуу хийгээд жигшүүрт сүмийн “хүслэн болохыг буюу.

9 Мөн түүнчлэн тэд дэлхийн магтаалын төлөө Бурханы гэгээнтнүүдийг “устгаж, мөн тэднийг боолчлолд оруулах бөлгөө.

10 Мөнхүү улиран тохиох дор би харж мөн их усыг болгоов; мөн тэр нь харийнханыг миний ах нарын үр удмаас тусгаарлаж байв.

11 Мөнхүү улиран тохиох дор сайхь тэнгэр элч надад хандан хэлэв: Болгоогтун Бурханы хилэгнэл ах нарын тань үр удам дээр байх буюу.

12 Мөн би харж бас харийнханы дунд буй, их усаар ах нарын маань үр удмаас тусгаарлагдсан нэгэн хүнийг болгоов; мөн би Бурханы “Сүнс доош бууж мөн тэр хүний дээр нөлөөлөхийг болгоов; мөн тэрбээр урагшлан их усанд одож, бүр амлагдсан нутагт байсан ах нарын маань үр удамд хүрэв.

13 Мөнхүү улиран тохиох дор харийнханы өөр зарим дээр нь Бурханы Сүнс нөлөөлснийг би болгоов; мөн тэд боолчлолоос гарч, их усанд одсон болой.

14 Мөнхүү улиран тохиох дор амлалтын “нутагт харийнханы ⁶олон ард түмэн байхыг

13 4a су Харийнхан.

б 1 Ниф. 13:26, 34;
14:3, 9–17.

5a Илч. 17:3–6;

1 Ниф. 14:13.

б Иер. 28:10–14.

6a С ба Г 88:94.

су Чөтгөр—

чөтгөрийн сүм.

б 1 Ниф. 22:22–23.

7a Морм. 8:36–38.

8a Илч. 18:10–24;

Морм. 8:35–38.

9a Илч. 13:4–7.

12a су Сүнсний

удирдамж,

сүнслэгээр

нөлөөлөгдөх.

14a су Амлалтын нутаг.

б 2 Ниф. 1:11;

Морм. 5:19–20.

би болгоов; мөн Бурханы хилэгнэл ах нарын маань үр удмын дээр байсныг би болгоов; мөн тэд харийнханы өмнө “тараагдаж бас бут цохигдсон болой.

15 Мөн би Их Эзэний Сүнснийг, тэр нь харийнхан дээр байсныг, мөн тэд дэгжиж өв залган эзэмших “нутагтай болсныг болгоов; мөн тэд цагаан байсныг, бас үлэмж хонгор мөн “үзэсгэлэн гоо, миний ардын “хөнөөгдөхөөсөө өмнө байсантай адил байхыг би болгоов.

16 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, боолчлолоос ангижран гарсан харийнхан Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусгахыг болгоов; мөн Их Эзэний хүч “тэдэнтэй орших буюу.

17 Мөн эх нутгийнхан нь болох тэр Харийнхан тэдний эсрэг тулалдахаар усан дээр, түүнчлэн газар дээр ч нэгдэн цугларсан байхыг би болгоов.

18 Мөн Бурханы хүч тэдэнтэй оршиж, мөн Бурханы хилэгнэл тэдний эсрэг тулалдахаар нэгдэн цугларах тэд бүгдийн дээр байхыг түүнчлэн би болгоов.

19 Мөн би, Нифай, боолчлолоос гарсан харийнхан, Бурханы хүчээр бусад бүх үндэстний гараас “чөлөөлөгдөхийг үзэв.

20 Мөнхүү улиран тохиох

дор би, Нифай, тэд уг нутагт дэвжсэнийг болгоов, мөн тэдний дунд тараагдсан нэгэн “номыг би үзэв.

21 Мөн сайхь тэнгэр элч надад хандан: Уг номын учрыг мэдэх үү та? хэмээв.

22 Мөн би түүнд хандан: Миний бие мэдэх нь үгүй хэмээв.

23 Мөн тэрбээр: Болгоогтун, энэ нь Иудейн амнаас гарсан бөлгөө. Мөн би, Нифай, үүнийг болгоов; мөн тэрээр надад хандан хэлэв: Таны болгоож буй “ном нь Их Эзэний Израилын угсаатай хийсэн гэрээг тээсэн “иудейчүүдийн “цэдэг бөлгөө; мөн энэ нь түүнчлэн ариун бошиглогчдын олон бошиглолыг агуулах буюу; мөн энэ нь гуулин ‘ялтсууд дээр сийлэгдсэн тэдгээртэй адил цэдэг, гэвч тэдгээр нь тийм ч олон биш болой; тийм боловч, тэдгээр нь Израилын угсаатай хийсэн Их Эзэний гэрээнүүдийг агуулдаг; иймийн тул, тэдгээр нь харийнханд агуу их үнэт зүйл билээ.

24 Мөн Их Эзэний сайхь тэнгэр элч надад хандан хэлэв: Та уг ном Иудейн амнаас гарсныг болгоосон буюу; мөн энэ нь Иудейн амнаас гарахдаа арванхоёр төлөөлөгчийн гэрчлэх тэр Их Эзэний сайн мэдээний бүрэн байдлыг агуулж байв; мөн тэд Бурханы

14в 1 Ниф. 22:7–8.

су Израил—
Израилын
Тараагдалт.

15а 2 Ниф. 10:19.

б 2 Ниф. 5:21.

в Морм. 6:17–22.

16а С ба Г 101:80.

19а 2 Ниф. 10:10–14;

3 Ниф. 21:4;

Ифер 2:12.

20а 1 Ниф. 14:23.

23а 1 Ниф. 13:38;

2 Ниф. 29:4–12.

б 2 Ниф. 3:12.

в су Судрууд.

г 1 Ниф. 5:10–13.

Хурганд орших үнэний дагуу гэрчлэх буюу.

25 Иймийн тул, эдгээр зүйлүүд нь Бурханд орших үнэний дагуу “иудейчүүдээс одож ^бхарийнханд цэврээрээ очих бөлгөө.

26 Мөн тэдгээр нь Хурганы арванхоёр төлөөлөгчийн гараар иудейчүүдээс “харийнханд хүргэгдсэний дараа, ^багуу хийгээд жигшүүрт ^ссүмийн үүслийг, бусад бүх сүмүүдээс хамгийн жигшүүрт түүнийг та үзэж буй бөлгөө; учир нь болгоогтун, тэд Хурганы сайн мэдээнээс олон ^ттодорхой болоод хамгийн эрхэм үнэт хэсгүүдийг ^ззайлуулан авсан; мөн түүнчлэн Их Эзэний олон гэрээг тэд авч зайлуулсан бөлгөө.

27 Мөн тэд энэ бүгдийг үйлдсэн тэд Их Эзэний зөв замуудыг гажуудуулж болохын тулд, тэд хүмүүний үрсийн мэлмийг сохолж бас зүрх сэтгэлийг хатууруулахын тулд болой.

28 Иймийн тул, тэр ном агуу хийгээд жигшүүрт сүмийн гараар дамжсаны дараа, олон тодорхой болоод эрхэм үнэт зүйл Бурханы Хурганы ном болох тэрхүү номноос авч зайлуулагдсаныг та харсан бөлгөө.

29 Мөн эдгээр тодорхой болоод эрхэм үнэт зүйлүүд

зайлуулагдсаны дараа энэ нь харийнханы бүх үндэстнүүдэд очих болно; мөн, тийм ээ, бүр харийнхан боолчлолоос гарч одоход таны харсан тэр их усыг гатлан энэ нь харийнханы бүх үндэстнүүдэд очсоны дараа — Бурханы Хурган дахь илэрхий байдлын дагуу хүмүүний үрсийн ойлголтонд илэрхий болох, уг номноос зайлуулагдсан, олон тодорхой болоод эрхэм үнэт зүйлүүдийн учир — Хурганы сайн мэдээнээс зайлуулагдан авагдсан эдгээр зүйлүүдийн учир, үлэмж агуу олон нь бүдрэхийг, тийм ээ, үүний хэрээр Сатан тэднийг агуу хүчээр эзэмдэхийг та үзэж буй нь энэ болой.

30 Хэдий тийм ч, боолчлолоос гарч явсан тэр, Их Эзэн Бурхан таны эцэгтэй, түүний үр удам өв залгамжлан эзэмших болно хэмээн гэрээ байгуулсан тэр, мөн ^ннутгийн гадаргуу дээрх бусад бүх нутгуудаас дээгүүр хэмээгдэх сонгомол, тэр нутагт Бурханы хүчээр бүх үндэстнүүдийн дээр өргөмжлөгдсөн харийнхан; иймийн тул, ах нарын тань дунд буй таны үр удмын ^ццусыг бүрмөсөн устгахыг Их Эзэн Бурхан харийнханд үл зөвшөөрөхийг та харж байна.

31 Тэрбээр, харийнхан ах

25a 2 Ниф. 29:4–6;

С ба Г 3:16.

су Иудейчүүд.

б су Харийнхан.

26a Мат. 21:43.

б 1 Ниф. 13:4–6; 14:3,

9–17.

в су Урвалт—Эртний Христийн Сүмийн урвалт.

з 1 Ниф. 14:20–26;

ИТ 1:8.

д Морм. 8:33;

Моисе 1:41.

30a су Амлалтын нутаг.

б Алма 45:10–14.

нарын тань үр удмыг “устгахыг ч басхүү үл тэвчих бөлгөө.

32 Үүслийг нь таны харсан тэр “жигшүүрт сүмээр далдлагдсан тэр Хурганы сайн мэдээний тодорхой болоод эрхэм үнэт хэсгүүдийн учир харийнханы орсон байхыг нь таны харж буй аймшигтай нүдэн балай байдалд үүрд үлдэхийг ч Их Эзэн Бурхан үл тэвчинэ.

33 Иймийн тул Бурханы Хурга хэлэв: Би харийнханд нигүүлсэнгүй хандахын тулд Израилын угсааны үлдэгдэлд агуу их шүүлтээр зочлох болно.

34 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний тэнгэр элч надад хэлэв: Болгоогтун, Бурханы Хурга өгүүлсэн нь, намайг Израилын угсааны “үлдэгдэлд зочилсны дараа—мөн миний ярьж буй энэ үлдэгдэл нь эцгийн тань үр удмынх юм—иймийн тул, би тэдэнд шүүлтээр зочилж, мөн Харийнханы гараар тэднийг цохьсны дараа, мөн янхан эмсийн эх болсон жигшүүрт сүмээр далдлагдсан, Хурганы ^бсайн мэдээний хамгийн тодорхой болоод эрхэм үнэт хэсгүүдийн нь учир харийнхан үлэмж ихээр ^ббүдэрсний

дараа, Хурга өгүүллрүүн—тэр өдөр би харийнханд нигүүлсэнгүй хандах болно, үүний хэрээр би тэдэнд өөрийн хүчээр, тодорхой болоод эрхэм үнэтэй байх миний сайн мэдээнээс ихийг ‘авчрах болно хэмээн Хурга хэлэв.

35 Учир нь болгоогтун, Хурга хэлсэн нь: Би өөрийгөө чиний үр удамд үзүүлэх учир, миний тэдэнд тохинуулах, тодорхой болоод эрхэм үнэт олон зүйлийг тэд бичиглэх болно; мөн чиний үр удам, мөн түүнчлэн ах нарын чинь үр удам устгагдан, итгэлгүйдээ бууран доройтсоны дараа, болгоогтун, “эдгээр зүйлүүд харийнханд Хурганы хүч болон бэлгээр ирэхийн тул далдлагдах болно.

36 Мөн миний “хад болон миний аврал, миний ^бсайн мэдээ тэдгээрт бичиглэгдэх болно гэдгийг Хурга хэллээ.

37 Мөн миний “Сионыг байгуулахыг тэр өдөр эрэлхийлэх тэд ^бадислагдсан болой; учир нь, тэдэнд Ариун Сүнсний “бэлэг болон хүч байх буюу; мөн хэрэв тэд эцсээ хүртэл ‘тэвчвээс тэд хожмын өдөр өргөмжлөгдөх ажгуу, мөн Хурганы үүрдийн ^охаант улсад аврагдах болно; мөн

31a 2 Ниф. 4:7; 10:18–19;
Иаков 3:5–9;
Хил. 15:12;
3 Ниф. 16:8–9;
Морм. 5:20–21.

32a су Чөтгөр—
чөтгөрийн сүм.

34a су Иосеф, Иаковын
хүү.
б су Сайн мэдээ.

в 1 Ниф. 14:1–3;
2 Ниф. 26:20.

г С ба Г 10:62.
су Сайн мэдээний
сэргээлт.

35a 2 Ниф. 27:6; 29:1–2.
су Мормоны Ном.

36a Хил. 5:12;
3 Ниф. 11:38–39.
су Хад.

б 3 Ниф. 27:13–21.

37a су Сион.

б С ба Г 21:9.

в су Ариун Сүнсний
бэлэг.

г 3 Ниф. 27:16.
су Тэвчих.

д су Селестиел алдар
суу.

амар амгаланг, тийм ээ, агуу их баярт мэдээг “зарлах хэн боловч, уулсын дээр тэд хичнээн үзэсгэлэнтэй байх билээ.

38 Мөнхүү улиран тохиох дор би ах нарынхаа үр удмын үлдэгдлийг, мөн түүнчлэн Иудейн амнаас гарч ирсэн Бурханы Хурганы “номыг, тэр нь харийнханаас ах нарын маань үр удмын “үлдэгдэлд хүрч ирснийг болгоов.

39 Мөн энэ нь тэдэнд ирсний дараа, харийнханаас тэдэнд Хурганы хүчээр ирсэн, харийнхан болон ах нарын маань үр удмын үлдэгдэлд, мөн түүнчлэн газрын гадаргуугаар нэг тархсан байсан иудейчүүд бошиглогчдын мөн Хурганы арванхоёр төлөөлөгчийн цэдгүүд “үнэн гэдэгт “итгүүлэх бусад “номуудыг би болгоов.

40 Мөн тэнгэр элч надад хандан ярьж, хэлсэн нь: Таны харийнханы дунд харсан тэр “хожмын цэдгүүд, Хурганы арванхоёр төлөөлөгчийнх болох “эхний цэдгүүдийн үнэнийг “тогтоож, мөн эднээс авагдан зайлуулагдсан тэдгээр тодорхой болоод эрхэм үнэт зүйлсийг мэдүүлэх бөлгөө; мөн бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүст

Бурханы Хурга бол Мөнхийн Эцэгийн Хүү хийгээд дэлхийн “Аврагч; мөн бүх хүмүүн түүнд ирэх ёстой, эс бөгөөс тэд аврагдаж чадахгүй гэдгийг мэдүүлэх болно.

41 Мөн тэд Хурганы амаар тогтоогдох үгсийн дагуу ирэх ёстой; мөн Хурганы үгс таны үр удмын цэдгүүдэд Хурганы арванхоёр төлөөлөгчийн цэдгийн нэгэн адилаар мэдүүлэгдэх бөлгөө; иймийн тул тэд хоёул “нэгдмэл байдлаар бүтээгдэх болно; учир нь бүх дэлхий даяар “нэг Бурхан мөн нэг “Хоньчин буй.

42 Мөн тэрбээр бүх үндэстэнд, “иудейчүүдэд мөн түүнчлэн харийнханд аль алинд нь өөрийгөө үзүүлэх тэр цаг ирэх болно; мөн тэрээр иудейчүүд түүнчлэн харийнханд өөрийгөө үзүүлсний дараа, тэгээд тэрээр харийнханд түүнчлэн иудейчүүдэд өөрийгөө үзүүлэх болно, мөн “эцсийнх нь эхэнд, мөн “эхнийх нь эцэст байх болно.

БҮЛЭГ 14

Харийнхан дээр буух адислалууд

37e Иса. 52:7;
Мозая 15:14–18;
3 Ниф. 20:40.
38a 1 Ниф. 13:23;
2 Ниф. 29:4–6.
б Морм. 5:15.
39a 1 Ниф. 14:30.
б Езек. 37:15–20;
2 Ниф. 3:11–12.
в су Судрууд—Ирнэ хэмээн

бошиглогдсон судрууд.
40a 2 Ниф. 26:16–17;
29:12.
су Мормоны Ном.
б су Библи.
в Морм. 7:8–9.
г Мормоны Номны эхний хуудсыг үз.
Моисе 1:6.
41a Езек. 37:17.

б Дэд хууль 6:4;
Иохан 17:21–23;
2 Ниф. 31:21.
в су Сайн Хоньчин.
42a С ба Г 90:8–9; 107:33;
112:4.
б Иаков 5:63.
в Лук 13:30;
1 Ниф. 15:13–20.

болон зүхлүүдийн тухай тэнгэр элч Нифайд хэлэв— Зөвхөн хоёр сүм буй нь: Бурханы Хурганы сүм мөн чөтгөрийн сүм болой— Бүх үндэстнүүд дэх Бурханы Гэгээнтнүүд агуу хийгээд жигшүүрт сүмд хавчигдан гадуурхагдав— Төлөөлөгч Иохан дэлхийн төгсгөлийн тухай бичиглэсэн нь. Ойролцоогоор мээ 600–592 он.

Мөнхүү улиран тохиох дор, тэдний “тээглэх чулууг зайлуулан өөрийгөө үгээр, мөн түүнчлэн ^бхүчээр, чухамхүү үйлэнд үзүүлэх тэр өдөр, хэрэв ^вхарийнхан Бурханы Хургыг сонсох аваас—

2 Мөн Бурханы Хурганы эсрэг зүрх сэтгэлээ үл хатууруулах аваас, тэд таны эцгийн үр удмын дунд тоологдох болно; тийм ээ, тэд Израилын угсааныхны дунд “тоологдох болно; мөн тэд амлагдсан нутагт үүрд ^бадислагдсан хүмүүс байх болно; тэд дахин хэзээ ч боолчлолд хүргэгдэхгүй; мөн Израилын угсаа дахин хэзээ ч сарниулагдахгүй.

3 Мөн тэр хүмүүний сүнсийг доош тамд удирдаж болохын тулд, чөтгөр болон түүний хүүхдүүдээр үндэслэгдсэн, агуу хийгээд жигшүүрт сүмээр тэдэнд зориулагдан ухагдсан тэр агуу “нүх— тийм

ээ, хүмүүний устгалын тулд ухагдсан тэр агуу нүх нь түүнийг ухсан тэднээрээ дүүргэгдэх болно, тэдний бүрмөсөн устгалыг хүртэл хэмээн Бурханы Хурга хэлдэг; төгсгөл үгүй ^бтамд орхигдохоос бусдаар бодгаль устгагдах нь үгүй болой.

4 Учир нь болгоогтун, энэ нь чөтгөрийн боолчлолын дагуу, мөн түүнчлэн түүний өмнө ёсон бусыг болон жигшүүрт хэргийг үйлдэх тэд бүгдийн дээрх Бурханы шударга ёсны дагуу буюу.

5 Мөнхүү улиран тохиох дор сайхь тэнгэр элч, Нифай, надад хандаж, хэлсэн нь: Хэрэв харийнхан наманчлах аваас тэдэнд сайн болохыг та болгоосон билээ; мөн түүнчлэн Израилын угсаан дахь Их Эзний гэрээнүүдийн тухай та мэдэх бөлгөө; мөн түүнчлэн “наманчлаагүй хэн боловч эрсдэх ёстойг та сонссон билээ.

6 Тиймийн тул, хэрэв тэд Бурханы Хурганы эсрэг зүрх сэтгэлээ хатууруулах аваас харийнханд “халаг тохиох буюу.

7 Ийнхүү би хүмүүний үрсийн дунд агуу хийгээд “гайхамшигт үйлийг үйлдэх цаг ирэх болно хэмээн Бурханы

14 1а Иса. 57:14;
1 Ниф. 13:29, 34;
2 Ниф. 26:20.
б 1 Тес. 1:5;
1 Ниф. 14:14;
Иаков 6:2–3.
в 3 Ниф. 16:6–13.
су Харийнхан.
2а Гал. 3:7, 29;

2 Ниф. 10:18–19;
3 Ниф. 16:13; 21:6,
22; Абр. 2:9–11.
б 2 Ниф. 6:12; 10:8–14;
3 Ниф. 16:6–7; 20:27.
3а 1 Ниф. 22:14;
С ба Г 109:25.
б су Ял; Там.
5а су Наманчлах,

Наманчлал.
6а 2 Ниф. 28:32.
7а Иса. 29:14;
1 Ниф. 22:8;
2 Ниф. 27:26; 29:1–2;
С ба Г 4:1.
су Сайн мэдээний сэргээлт.

Хурга хэлэв; аль аль талд байх үүрдийнх болох тэрхүү үйл буюу, нэг талаас тэд энх амгалан болон ⁶мөнх амьдралд ороход үнэмших, эсвээс тэдний зүрх сэтгэлийн хатуу мөн санаа бодлын харалган байдалдаа орхигдсоноос миний өгүүлсэнчлэн, биеэрээ болон оюун санаагаараа ч чөтгөрийн ⁷боолчлолын дагуу доош боолчлолд, мөн түүнчлэн устгалд авчрагдах болно.

8 Мөнхүү улиран тохиох дор уг тэнгэр элч эдгээр үгсийг ярьсны дараа, тэрбээр надад хандан: Израилын угсааныхантай хийсэн Эцэгийн “гэрээг та санаж байна уу? хэмээв, би түүнд хандан, тийм ээ гэв.

9 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр надад хандан: Харрагтун, мөн жигшүүрт хэргүүдийн эх, үндэслэгч нь “чөтгөр болох тэр агуу хийгээд жигшүүрт сүмийг болгоогтун хэмээв.

10 Мөн тэрээр надад хандан: Зөвхөн “хоёр сүм буйг болгоогтун; нэг нь Бурханы Хурганы сүм, мөн ⁶нөгөө нь чөтгөрийн сүм бөлгөө; иймийн тул, Бурханы Хурганы сүмд эс харьяалагдах хэн боловч жигшүүрт хэргүүдийн эх болох агуу сүмд

харьяалагдана, мөн тэр нь бүх дэлхийн ⁶садар эм билээ.

11 Мөнхүү улиран тохиох дор би харж бас бүх дэлхийн садар эмийг мөн тэрээр их ⁶усан дээр суусныг болгоов: мөн ⁶тэр нь бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүсийн дунд, бүх дэлхийг эзэгнэх бөлгөө.

12 Мөнхүү улиран тохиох дор би Бурханы Хурганы сүмийг болгоов, мөн энэ нь их усан дээр суугч садар эмийн тэрхүү ёсон бус хийгээд жигшүүрт хэргүүдийн учир, тоогоороо “цөөн байв; хэдий тийм, Бурханы гэгээнтнүүд байсан Хурганы сүмийнхэн түүнчлэн ⁶бүх дэлхийн гадаргуугаар оршин байхыг би болгоов; мөн тэдний эзэмшил нь газрын гадаргуугаар бага байв, миний харсан тэр агуу садар эмийн ёсон бусын учир болой.

13 Мөнхүү улиран тохиох дор жигшүүрт үйлсийн агуу эх, харийнханы бүх улсуудын дундаас олон ардыг Бурханы Хурганы эсрэг “тулалдуулахаар бүх газрын гадаргууд нэгтгэн цуглуулахыг би болгоов.

14 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, Хурганы сүмийн гэгээнтнүүдийн дээр, мөн газрын гадаргуугаар нэг

7б су Мөнх амьдрал.

в 2 Ниф. 2:26–29;

Алма 12:9–11.

8а су Абрахамын Гэрээ.

9а 1 Ниф. 15:35;

С ба Г 1:35.

су Чөтгөр.

10а 1 Ниф. 22:23.

б 1 Ниф. 13:4–6, 26.

в Илч. 17:5, 15;

2 Ниф. 10:16.

11а Иер. 51:13;

Илч. 17:15.

б С ба Г 35:11.

12а Мат. 7:14;

3 Ниф. 14:14;

С ба Г 138:26.

б С ба Г 90:11.

13а Илч. 17:1–6; 18:24;

1 Ниф. 13:5;

С ба Г 123:7–8.

тархсан Их Эзэний гэрээ байгуулсан хүмүүс дээр буух Бурханы Хурганы хүчийг болгоов; мөн тэд ялгуусан алдар суунд зөв шударга байдал хийгээд Бурханы “хүчээр зэвсэглэсэн байв.

15 Мөнхүү улиран тохиох дор Бурханы хилэн агуу хийгээд жигшүүрт сүмийн дээр “цутгагдан, үүний хэрээр дэлхийн бүх үндэстэн ястнуудын дунд дайнууд болон дайны цуурхлууд байсныг би болгоов.

16 Мөн “дайн тулалдаан хийгээд дайны цуурхлууд жигшүүрт хэргүүдийн эхийн эзэгнэх бүх үндэстнүүдийн дунд эхлэхэд, сайхь тэнгэр элч надад хандаж, хэлрүүн: Болгоогтун, Бурханы хилэн янхан эмсийн эх дээр буй; мөн болгоогтун, та эдгээр бүх зүйлийг харж буй—

17 Мөн бүх дэлхийн агуу хийгээд жигшүүрт сүм, түүний үндэслэгч нь чөтгөр болох, садар эмсийн эх дээр Бурханы “хилэн цутгагдах тэрхүү 6өдөр ирэхэд, чухам тэр өдөр, Израилын угсааны хүмүүстэй түүний хийсэн тэр “гэрээнүүд биелэгдэх зам бэлтгэгдэж, Эцэгийн ‘ажил эхлэх болно.

18 Мөнхүү улиран тохиох дор сайхь тэнгэр элч надад

хандан ярьж, өгүүллрүүн: Харагтун! хэмээв.

19 Мөн би харж бас нэгэн хүнийг, мөн тэрээр цагаан орхимж өмссөнийг болгоов.

20 Мөн сайхь тэнгэр элч надад хандан: Хурганы арванхоёр төлөөлөгчийн “нэгийг болгоогтун хэмээв.

21 Болгоогтун, тэрээр эдгээр зүйлүүдийн үлдсэнийг харж бас бичиглэх болно; тийм ээ, мөн түүнчлэн тохион байсан олон зүйлийг.

22 Мөн түүнчлэн тэрээр дэлхийн төгсгөлийн талаар бичих болно.

23 Иймийн тул, түүний бичих зүйлүүд шударга бөгөөд үнэн бөлгөө; мөн болгоогтун, тэдгээр нь Иудейн амнаас үүсэхийг нь таны болгоосон тэр “номонд бичиглэгдэнэ; мөн тэд Иудейн амнаас үүссэн тэр цагт, өөрөөр хэлбэл, уг ном Иудейн амнаас үүссэн тэр цагт, бичиглэгдсэн тэр зүйлүүд нь тодорхой болоод нандин бас 6эрхэм үнэт, мөн бүх хүмүүнд ойлгоход хялбар байв.

24 Мөн болгоогтун, Хурганы энэ “төлөөлөгчийн бичиглэх зүйлүүд нь таны харсан олон зүйл байх бөлгөө; мөн болгоогтун, үлдсэнийг нь та харах болно.

25 Гэвч үүнээс хожим таны

14a Иаков 6:2;
С ба Г 38:32–38.

15a С ба Г 1:13–14.

б Марк 13:8;

С ба Г 87:6.

16a 1 Ниф. 22:13–14;
Морм. 8:30.

17a 1 Ниф. 22:15–16.

б су Эцсийн өдрүүд,

Хожмын өдрүүд.

в Морм. 8:21, 41.

су Абрахамын Гэрээ.

г 3 Ниф. 21:7, 20–29.

су Сайн мэдээний

сэргээлт.

20a Илч. 1:1–3;

1 Ниф. 14:27.

23a 1 Ниф. 13:20–24;

Морм. 8:33.

б 1 Ниф. 13:28–32.

24a Ифер 4:16.

үзэх зүйлийг та бичихгүй; учир нь тэдгээрийг тэр “бичвэл зохино хэмээн Бурханы Хурганы төлөөлөгчийг Их Эзэн Бурхан томилсон бөлгөө.

26 Мөн түүнчлэн байсан тэдэнд бусад бүх зүйлийг тэрээр үзүүлж, мөн тэд тэдгээрийг бичих буюу; мөн тэдгээр нь Хурган дахь үнэний дагуу Израилын угсаанд Их Эзэнээс зохих цагтаа эрхэм нандин байдлаараа уламжлагдан ирэхийн тул “лацдагдсан болно.

27 Мөн би, Нифай, тэнгэр элчийн хэлсэнчлэн, Хурганы төлөөлөгчийн нэр “Иохан гэдгийг сонссон бөгөөд ийн гэрчлэх бөлгөө.

28 Мөн болгоогтун, би, Нифай, өөрийн үзсэн болоод сонссон зүйлүүдийн үлдэгдлийг бичих нь надад хориглогдсон билээ; иймийн тул миний бичсэн зүйлүүд надад хангалттай; мөн би үзсэн зүйлүүдээсээ зөвхөн багахан хэсгийг бичиглэсэн ажгуу.

29 Мөн би “эцгийнхээ харсан зүйлийг харсан бөгөөд, мөн Их Эзэний тэнгэр элч тэдгээрийг надад мэдүүлсэн хэмээн би гэрчлэх бөлгөө.

30 Мөн эдүгээ би Сүнсэнд автагдсан үедээ харсан тэдгээр зүйлүүдийн талаар ярихаа төгсгөл болгоё; мөн миний харсан бүх зүйл бичигдээгүй хэдий ч, миний

бичсэн зүйлүүд “үнэн бөлгөө. Мөн энэ нь ийм болой. Амен.

БҮЛЭГ 15

Хожмын өдрүүдэд Лихайн үр удам харийнханаас сайн мэдээг хүлээн авах болно— Унаган мөчрүүд нь дахин залгаагдах чидуны модтой Израилын цугларалт адилтгагдсан бөлгөө— Нифай амьдралын модны тухай үзэгдлийг тайлбарлаж мөн ёсон бусыг үйлдэгчдийг зөв шударгыг үйлдэгчдээс салгах Бурханы шударга ёсны тухай яриу. Ойролцоогоор мээ 600–592 он.

Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, сүнсэнд автагдан байж, мөн эдгээр бүх зүйлийг үзсэний дараа эцгийнхээ майханд эргэж ирэв.

2 Мөнхүү улиран тохиох дор би ах нараа харав, мөн тэд миний эцгийн тэдэнд ярьсан зүйлүүдийн талаар өөр хоорондоо маргалдаж байв.

3 Учир нь Их Эзэнээс эс асуух аваас хүмүүн “ойлгоход бэрх олон агуу зүйлийг тэдэнд тэрбээр үнэнээр яриу; мөн тэд зүрх сэтгэлдээ хатуурхсаны учир, тиймийн тул тэд Их Эзэнд зохих ёсоор найдсан нь үгүй.

4 Мөн эдүгээ би, Нифай, тэдний зүрх сэтгэл хатуугийн учир, мөн түүнчлэн,

25а Иохан 20:30–31;
Илч. 1:19.

26а 2 Ниф. 27:6–23;
Ифэр 3:21–27; 4:4–7;

С ба Г 35:18;
ИС—Т 1:65.

27а Илч. 1:1–3.
29а 1 Ниф. 8.

30а 2 Ниф. 33:10–14.
15 3а 1 Кор. 2:10–12;
Алма 12:9–11.

өөрийн үзсэн зүйлүүдийн, мөн хүмүүний үрсийн агуу ёсон бусын тул тэдгээр нь зайлшгүй улиран тохиох ёстойг мэдсэний учир га- шуудан байсан бөлгөө.

5 Мөнхүү улиран тохиох дор зовлонгийнхоо учир би гунигт дарагдан байв, миний хүмүүсийн “устгалын учир, миний “зовлон бүхнээс илүү их хэмээн би ойлгож байлаа, учир нь би тэдний уналтыг харсан.

6 Мөнхүү улиран тохиох дор би “хүчийг хүлээн авсны дараа ах нартаа хандан ярьж, тэдний зөрчилдөөний шалт- гааныг мэдэхийг тэднээс хүсэв.

7 Мөн тэд: Болгоогтун, эц- гийнхээ чидун модны унаган мөчрүүдийн талаар, мөн түүнчлэн харийнханы талаар ярьсан үгсийг бид ойлгож чадахгүй байна хэмээв.

8 Мөн би тэдэнд хандан: Та нар Их Эзэнээс “лавласан уу? хэмээв.

9 Мөн тэд надад хэлэв: Бид тэгсэнгүй; учир нь Их Эзэн тийм ямар ч зүйлийг бидэнд мэдүүлсэн нь үгүй.

10 Болгоогтун, би тэдэнд хандан: Та нар яахан Их Эзэний зарлигийг эс дагах билээ? Зүрх сэтгэл тань

“хатуугийн учир та нар яагаад эрсдэх билээ? хэмээв.

11 Их Эзэний хэлсэн зүйлийг та нар үл санана гэж үү? — Хэрэв та нар зүрх сэтгэлээ үл хатууруулан, миний зар- лигуудыг дагахад хичээн- гүйлэн, мөн та нар хүлээн авна гэдэгтээ найдсаар, мөн надаас итгэлтэйгээр “асуух аваас, эдгээр зүйлүүд та нарт лавтайяа мэдүүлэгдэх болно.

12 Болгоогтун, бидний эцэгт байсан Их Эзэний сүнсээр Израилын угсаа чидуны мод- той зүйрлэгдсэнийг би та нарт хэлж байна; мөн болгоогтун, бид Израилын угсаанаас тасарч салгагдаагүй бил үү, мөн бид Израилын угсааны “мөчир биш бил үү?

13 Мөн эдүгээ, харийнханы бүрэн байдлаар унаган мөч- рүүд нь залгагдах талаар бидний эцгийн өгүүлсэн нь, бидний үр удам итгэлгүйдээ “доройтсон байх болно, тийм ээ, олон жилийн турш, мөн “Мессиа өөрийгөө хүмүүний үрсэд биеэр үзүүлснээс олон үеийн дараа, тэр хожмын өдрүүдэд, тэгээд Мессиагийн “сайн мэдээний бүрэн байдал харийнханд, мөн “харийнхнаас бидний үр удмын үлдэгдэлд ирэх болно гэсэн утгатай—

14 Мөн тэр өдөр бидний

5а су Дайсан.
б Инос 1:13;
Морм. 6:1.
6а Моце 1:10;
ИС—Т 1:20, 48.
8а Мозая 26:13;
Алма 40:3.
су Залбирал.
10а у Урвалт.

11а Иаков 1:5–6;
Инос 1:15;
Моро. 7:26;
С ба Г 18:18.
су Асуух.
12а Эхл. 49:22–26;
1 Ниф. 10:12–14;
19:24.
су Лихай, Нифайн

эцэг.
13а 1 Ниф. 12:22–23;
2 Ниф. 26:15.
б су Мессиа.
в су Сайн мэдээ.
г 1 Ниф. 13:42; 22:5–10;
С ба Г 14:10.
су Харийнхан.

“үр удмын үлдэгдэл, тэд бол Израилын угсааных гэдгээ, мөн тэд Их Эзэнтэй ^бгэрээт хүмүүс гэдгээ мэдэх болно; мөн тэгээд тэд өвөг дээдсийнхээ ^амэдлэгт мөн түүнчлэн эцэг өвгөд нь түүгээр тохинуулагдсан өөрсдийн Гэтэлгэгчийн сайн мэдээний тухай мэдлэгт ирж мөн мэдэх болно; иймийн тул тэд өөрсдийн Гэтэлгэгч мөн түүний сургаалын мөн чанарын мэдлэгт орох болно; тэд түүнд хэрхэн ирж бас аврагдахыг мэдэж болохын тулд буюу.

15 Мөн тэгээд тэр өдөр тэд баярлаж мөн өөрсдийн “хад болон аврал болох, өөрсдийн үүрдийн Бурханыг магтахгүй гэж үү? Тийм ээ, тэр өдөр, тэд жинхэнэ ^бусан үзмийн модноос хүч чадал мөн шим тэжээл хүлээн авахгүй гэж үү? Тийм ээ, тэд Бурханы жинхэнэ сүрэгт нийлэхгүй бус уу?

16 Болгоогтун, би та нарт хэлье, Тийм ээ; тэд Израилын угсааныхны дунд дахин санагдах болно; чидун модны унаган мөчрүүд учраас, жинхэнэ чидуны модонд тэд ^азалгагдах болно.

17 Мөн эцгийн маань дурдсан нь ийм утгатай болой; мөн тэрээр энэ нь тэд харийнханаар тараагдсанаас

хойш тэр болтол улиран тохиохгүйг дурдсан бөлгөө; мөн энэ нь харийнханы тусламжтайгаар ирэхийг дээр дурдсан, чухамдаа иудейчүүдээр өөрөөр хэлбэл, Израилын угсааныхнаар ^аэсэргүүцэгдэх чухам тэрхүү шалтгааны улмаас Их Эзэн өөрийн хүчийг харийнханд үзүүлж болохын тулд болой.

18 Иймийн тул, бидний эцэг зөвхөн бидний үр удмын тухай бус, харин эцсийн өдрүүдэд биелэгдэх ёстой гэрээг дурдан, бүх Израилын угсааны тухай түүнчлэн ярьсан бөлгөө; Их Эзэнээс бидний эцэг Абрахамтай хийсэн, чиний “үр удмаар газар дэлхийн бүх үндэстэн адислагдах болно хэмээн өгүүлэх тэрхүү гэрээ буюу.

19 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, тэдэнд хандан эдгээр зүйлүүдийн талаар ихийг ярив; тийм ээ, хожмын өдрүүд дэх иудейчүүдийн ^асэргээлтийн талаар би тэдэнд ярьсан болой.

20 Мөн би тэдэнд Израилын угсааны, өөрөөр хэлбэл иудейчүүдийн сэргээлтийн талаар ярьсан ^аИсаиагийн үгсийг тоочив; мөн тэд сэргээгдсэнийхээ дараа дахин бусниулагдахгүй, бас дахин тараагдах ч үгүй. Мөнхүү

14а 2 Ниф. 10:2;

3 Ниф. 5:21–26;
21:4–7.

б су Абрахамын Гэрээ.

в 2 Ниф. 3:12; 30:5;

Морм. 7:1, 9–10;

С ба Г 3:16–20.

Мормоны Номны
эхний хуудсыг үз.

15а су Хад.

б Эхл. 49:11;

Иохан 15:1.

16а Иаков 5:60–68.

17а су Цовдлуулалт.

18а Эхл. 12:1–3;

Абр. 2:6–11.

19а 1 Ниф. 19:15.

су Израил—

Израилын

цугларалт.

20а 1 Ниф. 19:23.

улиран тохиох дор би ах нар-таа хандан олон үгсийг ярив, иймээс тэд тайтгарлыг олж мөн Их Эзэний өмнө өөрсдийгөө ^бдаруу төлөв болгов.

21 Мөнхүү улиран тохиох дор тэд надад хандан дахин ярьж, хэлсэн нь: Бидний эцгийн үзсэн зүүдэн дэх энэ зүйл ямар утгатай билээ? Түүний харсан тэр “мод ямар утгатай билээ? гэв.

22 Мөн би тэдэнд хандан энэ нь амьдралын “модыг төлөөлсөн бөлгөө хэмээв.

23 Мөн тэд надад хандан: бидний эцгийн үзсэн, уг модны зүг удирдсан тэр төмөр “барилул ямар утгатай вэ? хэмээв.

24 Мөн би тэдэнд хандан энэ нь Бурханы “үг байсныг хэлэв; мөн Бурханы үгийг анхааран сонсох, мөн үүнээс ^бзууран барих хэн боловч, тэд хэзээ ч эрсдэх нь үгүй; бас “хортны ‘уруу таталтууд хийгээд ^агалт сумнууд, тэднийг устгал уруу удирдахаар тэднийг харалган болгож давамгайлах нь ч үгүй.

25 Иймийн тул, би, Нифай, Их Эзэний үгэнд “анхаарал тавихыг тэдэнд ухуулав; тийм ээ, Бурханы үгэнд анхаарал тавин мөн түүний зарлигуудыг бүх зүйл дээр үргэлж

дагахыг сана хэмээн өөрийн бодгалийн бүх эрч хүчээр мөн өөрт буй бүх чадавхиараа тэдэнд ухуулсан бөлгөө.

26 Мөн тэд надад хандан: бидний эцгийн харсан уст “голын утга юун билээ? хэмээв.

27 Мөн би тэдэнд хандан эцгийн минь харсан тэр “ус бол ^ббузар байдал хэмээв; мөн түүний оюун өөр зүйлүүдэд хандсан байсны улмаас тэр усны бузрыг эс болгоосон буюу.

28 Мөн би тэдэнд хандан энэ нь аймшигт “ангал, амьдралын модноос мөн түүнчлэн Бурханы гэгээнтнүүдээс ёс бусыг үйлдэгчдийг зааглах тэр аймшигт ангал байсан бөлгөө.

29 Мөн би тэдэнд хандан энэ нь ёс бусыг үйлдэгсдэд бэлтгэгдсэн болохыг сайхь тэнгэр элч надад хэлсэн тэрхүү, аймшигт “тамын дүрслэл байсан хэмээв.

30 Мөн би тэдэнд хандан, бидний эцэг түүнчлэн Бурханы “шударга ёс нь ёс бусыг үйлдэгсдийг зөв шударгыг үйлдэгсдээс түүнчлэн зааглан хуваасныг харсан бөлгөө; мөн түүний гялалзах нь Бурханд үүрд болон үргэлж, мөн төгсөлгүйгээр дүрэлзэх галын гялалзах лугаа адил байсныг хэлсэн бөлгөө.

20б 1 Ниф. 16:5, 24, 39.

21а 1 Ниф. 8:10–12.

22а 1 Ниф. 11:4, 25;
Моце 3:9.

23а 1 Ниф. 8:19–24.

24а су Бурханы Үг.

б 1 Ниф. 8:30;

2 Ниф. 31:20.

в су Четгөр.

г 1 Ниф. 8:23.

су Уруу татах, Уруу таталт.

д Ефес 6:16;

С ба Г 3:8; 27:17.

25а С ба Г 11:2; 32:4;
84:43–44.

26а 1 Ниф. 8:13.

27а 1 Ниф. 12:16.

б су Бузар, Бузар явдал.

28а Лук 16:26;

1 Ниф. 12:18;

2 Ниф. 1:13.

29а су Там.

30а су Шударга ёс.

31 Мөн тэд надад хандан: энэ зүйл “сорилтын өдрүүдэд биеийн зовлонг илтгэх эсвээс, цаг зуурын махбодийг ^бүхсэний дараа сүнсний эцсийн байдлыг илтгэх буюу, эсвээс цаг зуурын зүйлийг хэлж байгаа юм уу? хэмээв.

32 Мөнхүү улиран тохиох дор би тэдэнд хандан энэ нь биеийн болон оюун санааны зүйлүүдийн аль алиныг нь төлөөлж байсныг хэлэв; учир нь тэд өөрсдийн “үйлсээр шүүгдэх ёстой тэрхүү өдөр ирнэ, тийм ээ, бүр зуурдын бие махбодиор тэдний сорилтын өдрүүдэд үйлдэгдсэн тэрхүү үйлсээр буюу.

33 Иймийн тул, хэрэв тэд өөрсдийн ёс бус үйлэнд “насыг юүлбээс тэд түүнчлэн зөв шударгад хамаарагдах оюун санааны тэр зүйлүүдийн хувьд ^бзайлуулагдах ёстой; иймийн тул, тэд өөрсдийн “үйлсээр ‘шүүгдэхийн учир Бурханы өмнө зогсохоор авчрагдах ёстой; мөн хэрэв тэдний үйлс бузар байсан аваас тэд ч ^обузар байх ёстой нь зайлшгүй; мөн хэрэв тэд бузар аваас тэд Бурханы хаант улсад ^ооршиж чадахгүй байх нь гарцаагүй; хэрэв ингэвээс,

Бурханы хаант улс түүнчлэн бузар байх ёстой.

34 Гэвч болгоогтун, би та нарт хэлье, Бурханы хаант улс бол “бузар бус, мөн өчүүхэн ч цэвэр бус зүйл Бурханы хаант улсад орж чадахгүй; иймийн тул бузар гэгдэх түүнд бэлтгэгдсэн бузар байр байх л ёстой.

35 Мөн тийм байр бэлтгэгдсэн, тийм ээ, бүр миний ярьсан тэр, мөн “чөтгөр бэлтгэгч нь болох тэр аймшигт ^бтам; иймийн тул хүмүүний сүнсний сүүлийн байдал Бурханы хаант улсад оршино, эсвээс миний ярьсан “шударга ёсны учир зайлуулагдана.

36 Иймийн тул, ёс бусыг үйлдэгсэд нь зөв шударгыг үйлдэгсэд болон амьдралын “модноос тусгаарлагдах болно, жимс нь бусад бүх жимснээс илүү хамгийн үнэт мөн хамгийн ^бхүсэл татам болох тэр болой; тийм ээ, мөн энэ нь Бурханы бүх “бэлэгнүүдээс хамгийн ‘агуу нь билээ. Мөн би ах нартаа ийн ярьсан бөлгөө. Амен.

БҮЛЭГ 16

Ёс бусыг үйлдэгчдэд үнэн хатуу

31a Алма 12:24; 42:10;
Хил. 13:38.

б Алма 40:6, 11–14.

32a су Ажлууд.

33a Мозая 15:26;

Моро. 10:26.

б Алма 12:12–16; 40:26.

в 3 Ниф. 27:23–27.

г су Эцсийн шүүлт.

д 2 Ниф. 9:16;

С ба Г 88:35.

е Дуул. 15:1–5; 24:3–4;

Алма 11:37;

С ба Г 76:50–70;

Моисе 6:57.

34a су Бузар, Бузар
явдал.

35a 1 Ниф. 14:9;

С ба Г 1:35.

б 2 Ниф. 9:19;

Мозая 26:27.

су Там.

в су Шударга ёс.

36a Эхл. 2:9;

2 Ниф. 2:15.

б 1 Ниф. 8:10–12;

Алма 32:42.

в С ба Г 14:7.

су Мөнх амьдрал.

г С ба Г 6:13.

санагддаг — Лихайн хөвгүүд Ишмэилийн охидтой гэрлэв — Лиахона тэдний замыг аглаг буйдад удирдав — Их Эзэний зарууд Лиахона дээр үе үед бичигдэх буюу — Ишмэил нас барав; түүний гэр бүлийнхэн зовлон зүдгүүрийн учир бувтналдав. Ойролцоогоор мээ 600–592 он.

Мөнхүү эдүгээ улиран тохиох дор би, Нифай, ах нартаа хандсан яриагаа төгсгөл болгосны дараа, болгоогтун, тэд надад хандан: Бидний тэвчих чадлаас хэтэрсэн хатуу зүйлийг чи бидэнд айлдав хэмээв.

2 Мөнхүү улиран тохиох дор тэдэнд хандан би үнэний дагуу ёсон бусыг үйлдэгсдийн эсрэг хатуу зүйлийг ярьсан гэдгээ би мэдсэн гэж хэлэв; мөн би зөв шударгыг үйлдэгсдийг зөвтгөн, мөн тэд хожмын өдөр өргөмжлөгдсөн байхыг гэрчлэв; иймийн тул “гэмтнүүдэд, энэ нь тэдний зүрхийг “зүсэх учир “үнэн хатуу санагдах бөлгөө.

3 Мөн эдүгээ ах нар минь, хэрэв та нар зөв шударга мөн үнэнийг дуртайяа анхааран сонсдог, мөн Бурханы өмнө үнэн шударгаар “явж болохын тул үүнд анхаарлаа хандуулдагсан бол, та нар үнэний учир бувтналдаж: Чи бидний эсрэг хэцүү зүйлийг яриу хэмээхгүй байсан.

4 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, Их Эзэний зарлигуудыг дага хэмээн байдгаараа хичээнгүйлэн ах нартаа ухуулав.

5 Мөнхүү улиран тохиох дор тэд Их Эзэний өмнө өөрсдийгөө “даруусгав; үүний хэрээр тэднийг зөв шударгын замаар алхлах болов уу хэмээх их найдлага мөн баясал надад төрөв.

6 Эдүгээ, эдгээр бүх зүйл Лемүелийн гэж түүний нэрлэсэн тэр хөндийд эцэг минь майханд оршин сууж ахуйд хэлэгдсэн мөн хийгдсэн бөлгөө.

7 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, Ишмэилийн “охидын нэгийг “эхнэр болгон авав; мөн түүнчлэн, миний ах нар Ишмэилийн охидыг эхнэр болгон авцгаав; мөн түүнчлэн “Зорам Ишмэилийн ууган охиныг эхнэр болгон авав.

8 Мөн тийн миний эцэг түүнд өгөгдсөн Их Эзэний бүх зарлигийг гүйцэлдүүлсэн байв. Мөн түүнчлэн би, Нифай Их Эзэнээр адислагдсан нь үлэмж бөлгөө.

9 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний дуу хоолой эцэгт минь хандан шөнөөр ярьж, мөн тэр ирэх өдөр аглаг буйдад өөрийн аянаа хөөвөл зохино хэмээн түүнд зарлигласан бөлгөө.

16 2a Иохан 3:20;
2 Ниф. 33:5;
Инос 1:23; Хил. 14:10.
су Гэм.
б Үйлс 5:33;
Мозая 13:7.

в Сур. үгс 15:10;
2 Ниф. 1:26; 9:40;
Хил. 13:24–26.
3a С ба Г 5:21.
су Алхах,
Бурхантай хамт

алхах.
5a 1 Ниф. 16:24, 39; 18:4.
7a 1 Ниф. 7:1.
б су Гэрлэлт, Гэрлэх.
в 1 Ниф. 4:35;
2 Ниф. 5:5–6.

10 Мөнхүү улиран тохиох дор эцэг минь өглөө дээшлэн мөн майхны үүдэнд ирэхдээ гайхал бахдалыг нь төрүүлэн газарт буй уран чамин хийцтэй “бөмбөрцгийг олж харав; мөн энэ нь сайн чанарын гууль байв. Мөн тэр бөмбөрцөг хоёр зүүтэй байв; нэг зүү нь аглаг буйдад бидний хааш явбал зохих замыг заах болой.

11 Мөнхүү улиран тохиох дор бид аглаг буйд тийш авч явбал зохих зүйлүүдээ, мөн Их Эзэн бидэнд өгсөн хоол хүнсний бүх үлдэгдлийг нэгтгэн цуглуулав; мөн бид зүйл бүрийн үрийг аглаг буйдад тээхээр авав.

12 Мөнхүү улиран тохиох дор бид майхнуудаа авч, Лемений голыг гатлан аглаг буйд тийш одов.

13 Мөнхүү улиран тохиох дор бид дөрвөн өдрийн турш зүүн урд, урд зүгийг баримжаалан аялаад, мөн бид майхнуудаа дахин босгов; мөн бид уг нутгийг Шазер хэмээх нэрээр нэрлэв.

14 Мөнхүү улиран тохиох дор бид нум сумаа агсан, мөн гэр бүлийнхэндээ хүнс бэлтгэхээр аглаг буйдад одов; мөн бид гэр бүлийнхэндээ зориулж ан агнаад дараа нь аглаг буйд дахь Шазер нутагт гэр бүлийнхэндээ эргэж ирэв. Тэгээд бид урьдын адил чигийг барин, аглаг буйдын “Улаан Тэнгисийн эрэг дагуу орших хамгийн шимт сайхан

хэсгийг даган аглаг буйдад дахин одов.

15 Мөнхүү улиран тохиох дор бид нум сумаараа болон чулуу хийгээд дүүгүүрээрээ замдаа ан хийж, олон өдрийн турш аялав.

16 Мөн бид аглаг буйдын арай илүү үржил шимтэй сайхан хэсгээр нь дагуулах тэр бөмбөрцгийн “заах чиглэлийг дагаж явсан бөлгөө.

17 Мөн бид олон хоногийн турш аялсныхаа дараа бид хэсэг хугацаанд өөрсдийгөө дахин амрааж мөн гэр бүлийнхэндээ хүнс залгуулахаар майхнуудаа босгон буудаллав.

18 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай ан агнахаар явахдаа, болгоогтун, сайн “гангаар хийсэн нумаа хугалчихав; тэгээд би нумаа хугалсны дараа, болгоогтун, ах нар маань намайг нумаа алдаж, бид хүнс залгуулаагүйн учир надад уурлав.

19 Мөнхүү улиран тохиох дор бид гэрийнхэндээ хүнсгүй буцаж ирэв, тэд аяныхаа улмаас ихэд эцэж ядарсан учир хоол хүнсээр гачигдаж ихэд шаналан байв.

20 Мөнхүү улиран тохиох дор Лемен болон Лемүел мөн Ишмэилийн хөвгүүд аглаг буйд дахь зовлон болон зүдгүүрүүдийнхээ улмаас үлэмж ихээр бувтналдаж эхлэв; мөн түүнчлэн эцэг минь Их Эзэн Бурханыхаа эсрэг бувтнаж

10a Алма 37:38–46.

су Лиахона.

14a С ба Г 17:1.

16a 1 Ниф. 16:10, 16, 26;

18:12;

Алма 37:38–46.

18a 2 Сам. 22:35.

эхлэв; тийм ээ, мөн тэд бүгд бүр Их Эзэний эсрэг бувтналдахаар тийм их үлэмжийн уй гашууд автагдсан байв.

21 Эдүгээ улиран тохиох дор би, Нифай, нумаа алдсан мөн тэдний нум хөвчгүй байсан учир ах нартайгаа хамт зовон байв, үлэмж хэцүү болж эхлэв, тийм ээ, үүний хэрээр бид хүнс залгуулж чадахгүй бомоо.

22 Мөнхүү улиран тохиох дор тэд зүрх сэтгэлээ дахин хатууруулж, бүр Их Эзэн Бурханыхаа эсрэг “гомдоллож байсан учир би, Нифай, ах нартаа хандан ихийг ярив.

23 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, модоор нум, шулуун саваагаар сум хийв; иймийн тул, би өөрийгөө нум сум, дүүгүүр бас чулуугаар зэвсэглэв. Мөн би “эцэгтээ хандан: Хааш одож би хүнс залгуулах билээ хэмээв.

24 Мөнхүү улиран тохиох дор тэд миний үгсийн учир өөрсдийгөө төлөв даруу болгосон тул тэрээр Их Эзэнээс “гуйв; өөрөөр хэлбэл би бодгалийнхаа эрч хүчээр тэдэнд хандан олон зүйлийг ярьсны учир болой.

25 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний дуу хоолой эцэгт минь ирэв; мөн тэрээр Их Эзэний эсрэг бувтнасан учир тэр үнэхээр “зэмлэгдсэн бөлгөө үүний хэрээр тэр гүнээ харамсалд орсон байв.

26 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний дуу хоолой түүнд хандан: Бөмбөрцгийн дээрхийг хар, мөн бичигдсэн зүйлийг болгоогтун хэмээв.

27 Мөнхүү улиран тохиох дор эцэг минь бөмбөрцөг дээр бичигдсэн тэр зүйлийг хараад, тэрээр, мөн түүнчлэн миний ах нар болон Ишмэилийн хөвгүүд мөн бидний эхнэрүүд үлэмж ихээр айж, чичирцгээж байв.

28 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, уг бөмбөрцөгт буй зүүнүүдийг болгоов, тэдгээр нь бидний тэдгээрт хандуулсан “итгэл болон хичээнгүй байдал хийгээд анхаарлын дагуу ажилладаг байв.

29 Мөн тэдгээрийн дээр түүнчлэн уншихад илэрхий, Их Эзэний замын талаар бидэнд “ойлголт өгөх шинэ бичиглэл байв; мөн энэ нь түүнд хандах бидний итгэл хичээл зүтгэлийн дагуу цагаас цагт өөрчлөгдөн бичигдэж байсан ажгуу. Мөн бид тийн “өчүүхэн арга замаар Их Эзэн агуу үйл хэргүүдийг тохиох болгож чадахыг харав.

30 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, бөмбөрцөг дээр өгөгдсөн тэр чиглэлийн дагуу уулын оргилыг зүглэн явлаа.

31 Мөнхүү улиран тохиох дор би зэрлэг амьтан агнаж,

22a Ег. 16:8; Тоол. 11:1.

23a Ег. 20:12;

Мозая 13:20.

24a су Залбирал.

25a Ифер 2:14.

су Зэмлэх, Зэмлэл.

28a Алма 37:40.

су Итгэл.

29a су Мэдлэг.

б Хаад. дэд 5:13;

Иаков 3:4;

Алма 37:6–7, 41;

С ба Г 123:16.

чингээд би гэр бүлийнхэндээ хүнс залгуулав.

32 Мөнхүү улиран тохиох дор би алсан амьтнаа үүрсээр майхнууддаа эргэж ирэв; мөн эдүгээ тэд намайг хүнс олж ирснийг хараад, тэдний баяр хөөр хичнээн их байсан гээч! Мөнхүү улиран тохиох дор тэд Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусган, мөн түүнд талархал мэдүүлэв.

33 Мөнхүү улиран тохиох дор бид дахин аяны харгуйг хөөн, эхний удаад аялсантай ойролцоо чиглэлд явав; мөн бид олон хоногийн турш аялаад бид хэсэг хугацаанд буудаллахаар майхнуудаа дахин босгов.

34 Мөнхүү улиран тохиох дор “Ишмэил нас барж, мөн Нахом хэмээх нутагт оршуулагдав.

35 Мөнхүү улиран тохиох дор Ишмэилийн охид эцгээ алдсан учир, басхүү аглаг буйд дахь “зовлон зүдгүүрүүдийн учир үлэмж гашуудан байв; мөн тэд эцгийн минь эсрэг, тэр тэднийг Иерусалим газраас авчирсны учир бувтналдан, өгүүлсэн нь: Бидний эцэг үхэв; тийм ээ, бид аглаг буйдад ихээр бэдрэв, мөн бид зовж зүдэрч, өлсөж цанган бас ядарч ихэд зовов; мөн эдгээр бүх зовлонгуудын эцэст бид энэ аглаг буйдад өлсгөлөнгийн улмаас эрсдэх буйза хэмээв.

36 Мөн тэд тийн эцгийн

минь эсрэг, мөн түүнчлэн миний эсрэг бувтналдав; мөн тэд Иерусалимын зүг дахин буцах хүсэлтэй байлаа.

37 Мөн Лемеен, Лемүелд мөн түүнчлэн Ишмэилийн хөвгүүдэд хандан: Болгоогтун, ах нар биднийхээ “захирагч хийгээд багш болох үүргийг өөртөө авсан манай дүү Нифайг мөн түүнчлэн манай эцгийг бүгдээрээ ‘алцгаая хэмээв.

38 Эдүгээ, Их Эзэн түүнтэй ярьсан, мөн түүнчлэн “тэнгэр элчүүд түүнд тохинуулна гэж тэрээр хэлдэг. Гэвч болгоогтун, тэр бидэнд худал хэлж буйг бид мэднэ; мөн тэрээр бидний нүдийг хуурч болохын тулд, эдгээр зүйлийг тэр бидэнд хэлж мөн олон зүйлийг башир аргаар үйлдэн, магадгүй, биднийг харь этгээд аглаг буйд тийш дагуулан одож болно хэмээн бодож байгаа биз ээ; мөн тэр биднийг дагуулсны дараа тэр биднээр өөрийн дураар болон хүссэнийхээ дагуу хийлгэж болохын тулд тэр өөрийгөө бидний хаан мөн захирагч болгохыг бодсон ажээ. Мөн иймэрхүү маягаар миний ах Лемеен тэдний зүрх сэтгэлийг өдөөн хатгаж уурлуулав.

39 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн бидэнтэй хамт байв, тийм ээ, бүр Их Эзэний дуу хоолой ирж мөн тэдэнд хандан олон үгийг ярив, мөн тэднийг үлэмж “зэмлэсэн

34а 1 Ниф. 7:2–6.
35а су Дайсан.
37а Эхл. 37:9–11;

1 Ниф. 2:22; 18:10.
б 1 Ниф. 17:44.
су Аллага.

38а 1 Ниф. 3:30–31; 4:3.
39а су Зэмлэх, Зэмлэл.

бөлгөө; мөн тэд Их Эзэний дуу хоолойгоор зэмлэгдсэний дараа тэд уурлахаа больж, мөн нүглүүдээ наманчлав, үүний хэрээр Их Эзэн биднийг дахин хоол хүнсээр адисалсан тул бид эрсдээгүй бөлгөө.

БҮЛЭГ 17

Нифай усан онгоц барихаар зарлигдуулав—Ах нар нь түүнийг эсэргүүцэв—Тэрээр Израилынханд Бурханы үйлдсэн үйл хэргүүдийн түүхийг давтан байж тэднийг ухуулав—Нифай Бурханы хүчээр дүүргэдэв—Түүнд гар хүрэх нь ах нарт нь хориглогдож, эс бөгөөс тэд хатсан зэгс мэт гандах цээрлэлийг хүлээв. Ойролцоогоор мээ 592–591 он.

Мөнхүү улиран тохиох дор бид аглаг буйдад дахин аяндаа гарав; мөн бид тэр цагаас хойш барагцаалбал дорнодыг чиглэн аялсан бөлгөө. Мөн бид аялж бас аглаг буйдад зовлонгийн ихийг туулав; мөн манай бүсгүйчүүд аглаг буйдад хүүхдүүд төрүүлэв.

2 Мөн аглаг буйдад бид “түүхий махаар амь зогоож байхад манай эмэгтэйчүүд хүүхдүүдээ хөхөөр элбэг цатгаж, бас тэд хүч тамиртай байв, тийм ээ бүр эр хүний адил байв; мөн тэд аяны замыг дургүйцэлгүйгээр эхэлж тэсэхүйц бидэн дээрх Их

Эзэний адислалууд тийм агуу байв.

3 Мөн тийнхүү бид Бурханы зарлигууд биелэгдэх ёстойг харна. Мөн хүмүүний үрс Бурханы зарлигуудыг “дагавал тэрээр тэднийг асран мөн тэднийг хүчирхэгжүүлж, бас тэдэнд өөрийн зарлигласан зүйлийг гүйцэлдүүлж чадах арга замуудыг хангаж өгөх бөлгөө; иймийн тул, тэрээр биднийг аглаг буйдад нүүдэллэж байх зуур аливаа арга замуудаар ⁶хангаж байв.

4 Мөн бид олон жилийн турш нүүдлийн байдалд байв, тийм ээ, бүр найман жил аглаг буйдад байлаа.

5 Мөн жимс мөн түүнчлэн зэрлэг зөгийн бал элбэгтэй учир Өгөөмөр хэмээн бидний нэрлэсэн нутагт бид хүрч ирэв; мөн эдгээр бүх зүйл биднийг эрсдүүлэхгүйн тулд Их Эзэнээр бэлтгэгдсэн байлаа. Мөн Иррентум хэмээн бидний нэрлэсэн, орчуулбал их усан гэгдэх тэнгисийг бид харав.

6 Мөнхүү улиран тохиох дор бид тэнгисийн эрэгт майхнуудаа босгов; мөн бид их “зовлон, олон бэрхийг туулж, тийм ээ, бүр бид бүгдийг нь бичиж чадахааргүй ихийг буюу, гэсэн хэдий ч, бид тэнгисийн эрэгт ирэх үедээ үлэмж баяртай байв; мөн бид их жимстэйн учир уг нутгийг Өгөөмөр хэмээн нэрлэв.

7 Мөнхүү улиран тохиох дор

17 2а 1 Ниф. 17:12.
3а Мозая 2:41;
Алма 26:12.

су Дуулгавартай
байх, Дуулгавартай,
Дуулгавартай

дагах.
б 1 Ниф. 3:7.
6а 2 Ниф. 4:20.

би, Нифай, Өгөөмөр нутагт олон өдөр өнжсөний дараа Их Эзэний дуу хоолой надад ирж, өгүүлсэн нь: Бос, мөн ууланд гар хэмээв. Мөнхүү улиран тохиох дор би босч мөн уулан дээр гараад, Их Эзэнд хандан залбирав.

8 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн надад ярьж, өгүүлсэн нь: Би чиний хүмүүсийг энэ усыг гаталгахын тулд, чамд миний үзүүлэх тэр “жаягаар, чи усан онгоц барих болно хэмээв.

9 Мөн би хэлэв: Их Эзэн, би хааш одож надад таны үзүүлсэн тэр жаягийн дагуу онгоц барих багаж хийж болох хайлуулах хүдрийг олох билээ би?

10 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн багаж хийж болох хүдэр олохын тулд хааш явах ёстойг надад хэлэв.

11 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай амьтны ширээр, гал үлээлгэх хөөрөг хийв; мөн гал хөөргөдөх хэрэгсэлтэй байж болохын тулд би хөөрөг хийсний дараа, гал үүсгэж болохын тулд хоёр чулуу харшуулан цахив.

12 Учир нь, Их Эзэн эдүгээ болтол биднийг аглаг буйдад аялах зуураа гал өрдөхийг зөвшөөрөөгүй билээ; учир нь тэрээр хэлэв: би та нарын хүнсийг гал дээр “болгох шаардлагагүйгээр амт оруулна.

13 Мөн түүнчлэн аглаг

буйдад би та нарын гэрэл байх болно; мөн би та нарын өмнө замыг “бэлтгэнэ, хэрэв та нар миний зарлигуудыг дагавал; иймийн тул, та нар миний зарлигийг дагахын хэрээр, та нар “амлагдсан нутгийн зүг удирдагдах болно; мөн та нар надаар удирдагдаж байгаагаа “мэдэх болно.

14 Тиймээ, мөн Их Эзэн түүнчлэн хэлэв: Та нар амлагдсан нутагт хүрсний дараа, Их Эзэн, би бол “Бурхан мөн гэдгийг та нар “мэдэх болно; мөн Их Эзэн би, та нарыг устгалаас зайлуулсан; тийм ээ, би та нарыг Иерусалим нутгаас гаргаж авчирсныг буюу.

15 Иймийн тул, би, Нифай, Их Эзэний зарлигуудыг дагахаар мэрийсэн, мөн итгэлтэй бас хичээнгүй байхыг би ах нартаа ухуулсан билээ.

16 Мөнхүү улиран тохиох дор би хаднаас хайлуулсан хүдрээр багаж хийв.

17 Мөн ах нар маань намайг усан онгоц “барих гэж буйг хараад, тэд миний эсрэг бувтналдаж эхлэв, өгүүлсэн нь: Дүү маань мулгуу юм, учир нь тэр өөрийгөө усан онгоц барьж чадна хэмээн сэтгэнэ; тийм ээ, мөн түүнчлэн тэр энэ агуу их усыг гаталж чадна гэж бодох ажээ.

18 Мөн ийн ах нар минь миний эсрэг гомдоллож, мөн тэд намайг усан онгоц барьж

8а 1 Ниф. 18:2.
12а 1 Ниф. 17:2.
13а Алма 37:38–39.
б 1 Ниф. 2:20;

Иаков 2:12.
в Ег. 6:7.
14а С ба Г 5:2.
б 2 Ниф. 1:4.

су Гэрчлэл.
17а 1 Ниф. 18:1–6.

чадна гэж итгээгүйн учир, тэд хөдөлмөрлөхгүй байх хүсэлтэй байсан буюу; бас тэд намайг Их Эзэнээр зааварлагдаж байсан гэдэгт ч итгэсэнгүй.

19 Мөн эдүгээ улиран тохиох дор би, Нифай, тэдний зүрх сэтгэл хатуугийн учир үлэмж ихээр харамсан байв; мөн эдүгээ тэд намайг харамсаж эхлэхийг хараад дотроо баярлаж, үүнийхээ хэрээр тэд намайг давсандаа “эрэмшиж, өгүүлсэн нь: Бид чамайг усан онгоц барьж чадахгүйг чинь мэдсэн, учир нь чадал чинь хүрэхгүйг бид мэдсэн; иймийн тул, чи ийм агуу үйлийг гүйцэлдүүлж чадахгүй.

20 Мөн чи зүрх сэтгэлийнхээ мунхаг “төсөөлөлд хөтлөгдөх бидний эцэгтэй адил юм; тийм ээ, тэр биднийг Иерусалим нутгаас удирдан гаргасан, мөн бид аглаг буйдад өдий олон жил бэдрэн явна; мөн бидний эмэгтэйчүүд бие давхар байж хүнд ажилд зүтгэв; мөн тэд аглаг буйдад хүүхдүүдээ төрүүлж мөн бүх зүйлийн зовлонг, үхэхээс бусдыг л үзлээ; мөн тэд Иерусалимаас гарч ирэхээсээ өмнө үхсэн бол эдгээр зовлонгуудыг туулснаас хавьгүй дээр байх байсан биз ээ.

21 Болгоогтун, энэ олон жил бид аглаг буйдад зовов, бид өөрсдийн эд хөрөнгө болон өвлөсөн нутагтаа сайхан байж

болох байсан; тийм ээ, мөн бид баяр хөөртэй байж болох байсан.

22 Мөн Иерусалим газарт байсан тэдгээр хүмүүс “зөв шударга хүмүүс байсныг бид мэднэ; учир нь тэд Их Эзэний дүрмүүд болон шийдвэрүүдийг мөн түүний бүх зарлигуудыг Мосегийн хуулийн дагуу сахьдаг байсан бөлгөө; иймийн тул, тэд бол зөв шударга хүмүүс гэдгийг бид мэднэ; мөн бидний эцэг тэднийг шүүж, мөн бид түүний үгсийг анхааран сонсох учраас биднийг алсад удирдсан юм; тийм ээ, мөн бидний дүү түүнтэй адил юм. Мөн иймэрхүү маягийн хэлээр ах нар маань бидний эсрэг гомдоллон бувтналдав.

23 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, тэдэнд хандан ярьж, хэлрүүн: Израилын үр удам болох, бидний эцэг өвгөд хэрэв Их Эзэний үгсийг анхаараагүй сэн бол египетчүүдийн гараас гарах байсан гэдэгт та нар итгэдэг үү?

24 Тийм ээ, хэрэв тэднийг боолчлолоос “удирдан гаргахыг Их Эзэн Мосед зарлиг болгоогүй сэн бол, тэд боолчлолоос удирдагдан гарах байсан гэж бодно уу, та нар?

25 Эдүгээ Израилын хүүхдүүд “боолчлолд байсныг та нар мэднэ; мөн тэд тэсэхэд хэцүү тэр үүргийг тээж явсныг та нар мэднэ; иймийн

19a су Хавчих,
Хавчлага.

20a 1 Ниф. 2:11.

22a 1 Ниф. 1:13.

24a Ег. 3:2–10;

1 Ниф. 19:10;

2 Ниф. 3:9; 25:20.

25a Эхл. 15:13–14.

б Ег. 1:11; 2:11.

тул, тэд боолчлолоос гаргагдан авчрагдсан нь тэдэнд сайн зүйл болсон нь гарцаагүйг та нар мэднэ.

26 “Мосе тэр агуу үйлийг хийхээр Их Эзэнээс зарлиглагдсан байсныг эдүгээ та нар мэднэ; мөн та нар түүний ^бүгээр Улаан Тэнгисийн ус нааш цааш ярагдан, мөн тэд хуурай газар дээгүүр хөндлөн гарч ирснийг мэднэ.

27 Харин Фараоны их цэрэг болох тэр египетчүүд Улаан Тэнгист живснийг та нар мэднэ.

28 Мөн түүнчлэн тэд аглаг буйдад “манна гэгчээр тэжээгдэж байсныг та нар мэднэ.

29 Тийм ээ, мөн түүнчлэн Мосе өөрийн үгээр, түүнд байсан Бурханы хүчний дагуу хадыг “түншиж, тэндээс ус гарахад Израилын хүүхдүүд цангаагаа тайлж чадах болсныг та нар мэдэх бөлгөө.

30 Мөн тэдний өмнө явж, өдөр нь тэднийг дагуулан мөн шөнө нь гэрэл гэгээ өгч, мөн хүнд хэрэглэгдвэл “зохих тэдгээр бүх зүйлийг тэдэнд хийж өгсөн Их Эзэн Бурханаараа, өөрсдийн Гэтэлгэгчээр тэд удирдагдан байсан атал, тэд зүрх сэтгэлээ хатууруулан мөн оюунаа харалган

болгож, Мосегийн эсрэг мөн үнэн болоод амьд Бурханы эсрэг ^бхорон мууг өгүүлж байсан билээ.

31 Мөнхүү улиран тохиох дор өөрийн үгсийн дагуу тэр тэднийг “устгасан бөлгөө; мөн өөрийн үгсийн дагуу тэр тэднийг ^будирдаж; мөн өөрийн үгсийн дагуу тэр тэдэнд бүх зүйлийг хийж өгсөн билээ; мөн түүний үгээр бус нэгээхэн ч зүйл эс тохиов.

32 Мөн тэд Иордан голыг гаталсны дараа тэрээр тэднийг уг нутгийн хүүхдүүдийг “хөөн зайлуулахаар, тийм ээ, тэднийг устгалд нь хүргэн тараах хүчтэй болгосон буюу.

33 Мөн эдүгээ, та нар ийн бодно уу, амлалтын нутагт байсан, бидний эцэг өвгөдөөр хөөгдөн гаргагдсан, энэ нутгийн хүүхдүүдийг, тэднийг та нар зөв шударга байсан гэж бодно уу? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй.

34 Хэрэв тэд зөв шударга байсан бол бидний эцэг өвгөд тэднээс илүүтэйгээр сонгомол гэж та нар бодно уу? Би та нарт хэлнэ, Үгүй.

35 Болгоогтун, Их Эзэн бүх “биесийг адилтган үзнэ; ^бзөв шударга байгч тэрээр Бурханы ^бээл хишгийг хүртдэг.

26a Үйлс 7:22–39.

б Ег. 14:21–31;
1 Ниф. 4:2;
Мозая 7:19;
Хил. 8:11;
С ба Г 8:3;
Мосе 1:25.

28a Ег. 16:4, 14–15, 35;

Тоол. 11:7–8;
Дэд хууль 8:3;
Мозая 7:19.

29a Ег. 17:6; Тоол. 20:11;

Дэд хууль 8:15;
1 Ниф. 20:21.

30a С ба Г 18:18; 88:64–65.

б Ег. 32:8;
Тоол. 14:2–3;
Езек. 20:13–16;
С ба Г 84:23–25.

31a Тоол. 26:65.

б 1 Ниф. 5:15;
С ба Г 103:16–18.

32a Тоол. 33:52–53;

Иош. 24:8.

35a Үйлс 10:15, 34;

Ром 2:11;
2 Ниф. 26:23–33.
б Дуул. 55:22;
1 Ниф. 22:17.

в 1 Сам. 2:30;

Дуул. 97:10; 145:20;
Алма 13:4;
С ба Г 82:10.

Гэвч болгоогтун, энэ хүмүүс Бурханы үг бүрийг эсэргүүцэж, мөн тэдний алдас боловсорч гүйцээд байв; мөн Бурханы хилэн тэр чигээрээ тэдний дээр байв; мөн Их Эзэн уг нутгийг тэдний эсрэг болгон зүхэж, мөн бидний эцэг өвгөдийн төлөө үүнийг адисалсан юм; тийм ээ, тэрээр үүнийг тэдний эсрэг, устгалд нь хүртэл зүхэж, мөн тэрээр бидний эцэг өвгөдийг, үүнийг эзэмших хүчээр тэднийг адисалсан юм.

36 Болгоогтун, Их Эзэн “газар дэлхийг ^боршин суугчдынх нь төлөө ^ббүтээсэн юм; мөн тэрнийг тэднээр эзэмшүүлэхийн тулд тэрээр өөрийн хүүхдүүдийг бүтээсэн юм.

37 Мөн тэрээр зөв шударга үндэстнийг ^аөсгөн, мөн ёсон бусыг үйлдэгч үндэстнүүдийг устгах болно.

38 Мөн тэрээр зөв шударгыг үйлдэгчдийг эрхэм сайхан “нутаг тийш удирдаж, мөн ёсон бусыг үйлдэгчдийг тэрээр ^бустган, мөн тэдний улмаас, тэдэнд уг нутгийг зүхэх бөлгөө.

39 Тэрээр өндөр тэнгэрт ноёлдог, учир нь энэ бол түүний сэнтий, мөн энэ дэлхий бол түүний ^ахөлийн гишгүүр юм.

40 Мөн тэрээр өөрийг нь Бурханаа болгогч тэднийг хайрладаг. Болгоогтун, тэрээр бидний эцэг өвгөдийг хайрлаж, тийм ээ, бүр Абрахам, “Исаак мөн ^бИаковыг, мөн тэрээр тэдэнтэй ^агэрээ хийсэн билээ; мөн тэрээр өөрийн хийсэн гэрээнүүдийг санасан буюу; иймийн тул, тэрээр тэднийг ^гЕгипет газраас гарган авчирсан бөлгөө.

41 Мөн тэрээр өөрийн саваагаар аглаг буйдад тэднийг шийтгэв; учир нь тэд яг та нарын адил зүрх сэтгэлээ “хатууруулсан билээ; мөн Их Эзэн тэдний хорт явдлын улмаас тэднийг шийтгэв. Тэрээр харвагч хорт ^бмогойнуудыг тэдний дунд илгээсэн бөлгөө; мөн тэднийг хазуулсны дараа тэрээр ^аэдгэрч болох замыг бэлтгэсэн ажгуу; мөн тэдний гүйцэлдүүлэх ёстой ажил нь харах байв; мөн уг замын ^гэнгийн байдал эсвэл үүний амархны учир тэдгээрээс эрсэдсэн нь олон байв.

42 Мөн тэд цагаас цагт зүрх сэтгэлээ хатууруулж, мөн “Мосегийн эсрэг, мөн түүнчлэн Бурханы эсрэг тэд ^бхорт мууг өгүүлж байв; гэсэн хэдий ч, түүний зүйрлэшгүй

36a су Газар дэлхий.

б Иса. 45:18;

Абр. 3:24–25.

в су Бүтээх, Бүтээл.

37a Сур. үгс 14:34;

1 Ниф. 4:13; Ифер

2:10; С ба Г 117:6.

38a су Амлалтын нутаг.

б Лев. 20:22.

39a Иса. 66:1;

С ба Г 38:17; Абр. 2:7.

40a Эхл. 21:12;

С ба Г 27:10.

б Эхл. 28:1–5.

в су Абрахамын Гэрээ.

г Дэд хууль 4:37.

41a Хаад. дэд 17:7–23.

б Тоол. 21:4–9;

Дэд хууль 8:15;

Алма 33:18–22.

в Иохан 3:13–15;

2 Ниф. 25:20.

г Алма 37:44–47;

Хил. 8:15.

42a С ба Г 84:23–24.

б Тоол. 14:1–12.

су Эсэргүүцэл.

хүчээр амлалтын нутагт тэд удирдагдсаныг та нар мэднэ.

43 Мөн эдүгээ, эдгээр бүх зүйлийн дараа, тэдний ёсон бус байх цаг ирлээ, тийм ээ, бараг л бүрэн засарсан; мөн энэ өдөр тэд бараг устгагдах гэж байж ч магад, би эс мэднэ; учир нь боолчлолд хүргэгдэх тэдний цөөн хэдээс бусад нь устгагдах ёстой тэр өдөр гарцаагүй ирэх ёстойг би мэднэ.

44 Иймийн тул, тэрээр аглаг буйд тийш одвол зохино хэмээн Их Эзэн эцэгт минь “зарлигласан ажгуу; мөн түүнчлэн иудейчүүд түүний амийг авахыг эрэлхийлэв; тийм ээ, мөн ^бта нар ч түүнчлэн түүний амийг авахаар эрэлхийлсэн; иймийн тул, та нар зүрх сэтгэлдээ алуурчид, та нар бас тэдний адил болгоо.

45 Та нар алдсыг үйлдэхдээ “шаламгай боловч Их Эзэн Бурханаа санахдаа удаан юм. Та нар ^бтэнгэр элчийг харсан, мөн тэрээр та нарт ярьсан; тийм ээ, та нар түүний дуу хоолойг цагаас цагт сонссон; мөн тэрээр намуухан зөөлөн дуугаар та нарт ярьсан, гэвч та нар ^вмэдрэхээс өнгөрсөн, иймээс та нар түүний үгсийг мэдэрч чадсангүй; иймийн тул, дэлхий салж хуваагдах мэт сэгсрэх аянгын дуугаар тэрээр та нарт ярьсан билээ.

46 Мөн түүнчлэн тэрбээр өөрийн бүхнийг чадагч үгийн

“хүчээр газар дэлхийг ч үгүй болгож чадахыг та нар мэднэ; тийм ээ, мөн тэр өөрийн үгээр бартаатай газрыг тэгш сайхан, мөн тэгш сайхан нутгуудыг өвдэж чадахыг та нар мэднэ. Өө, тэгвэл, яагаад зүрх сэтгэлдээ ийм хатуу байж чадна вэ, та нар?

47 Болгоогтун, бодгаль минь та нараас болоод зовлондоо урагдаж, мөн зүрх сэтгэл минь өвднөм; та нарыг үүрд зайлуулагдах болуузай хэмээн айнам би. Болгоогтун, би Бурханы Сүнсээр “дүүрэн байнам, үүний хэрээр миний бие ^бхүчгүй байна.

48 Мөн эдүгээ улиран тохиох дор намайг эдгээр үгсийг ярьсны дараа тэд надад уурлаж, мөн намайг тэнгисийн гүнд хаяхыг хүсч байв; мөн тэд надад гар хүрэхээр урагшлан ирэхэд би тэдэнд ярьж, өгүүлсэн нь: Бүхнийг Чадагч Бурханы нэрээр, надад бүү “хүр хэмээн би та нарт зарлиглаж байна, учир нь бүр бүх биеийг минь төөнөх, Бурханы ^бхүчээр би дүүргэгдээд байна; мөн хэн надад гар хүрнэв тэр нь бүр хатсан зэгстэй адил ^вгандах болно; мөн тэрээр Бурханы хүчний өмнө юухан ч биш, учир нь Бурхан түүнийг цохих болно.

49 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, тэд эцгийнхээ эсрэг цаашид бувтналдах нь зохисгүй; бас Бурхан намайг

44a 1 Ниф. 2:1–2.

б 1 Ниф. 16:37.

45a Мозая 13:29.

б 1 Ниф. 4:3.

в Ефес 4:19.

46a Хил. 12:6–18.

47a Мика 3:8.

б 1 Ниф. 19:20.

48a Мозая 13:3.

б 2 Ниф. 1:26–27.

су Хүч.

в Хаад. дээд 13:4–7.

усан онгоц баривал зохино хэмээн зарлигласан тул, тэд надаас өөрсдийн хөдөлмөрийг харамлах учиргүй хэмээн тэдэнд хэлэв.

50 Мөн би тэдэнд хэлэв: “Хэрэв Бурхан надад бүх зүйлийг зарлигласан бол би тэдгээрийг хийж чадах бөлгөө. Хэрэв би энэ усанд газар бол гэж хэлбэл зохино хэмээн тэр надад зарлигласан бол энэ нь газар болох сон; мөн хэрэв би үүнийг хэлэх юм бол энэ нь гүйцэлдэх болно.

51 Мөн эдүгээ, хэрэв Их Эзэн ийм агуу их хүчтэй байж, мөн хүмүүний үрсийн дунд ийм олон гайхамшгийг гүйцэлдүүлсэн бол, усан онгоц барихыг яахан тэрээр надад “зааварлаж болохгүй байх билээ?

52 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, ах нартаа хандан олон зүйлийг хэлж үүний хэрээр тэд шившиглэгдэж мөн миний эсрэг маргаж чадсангүй; бүр олон хоногийн турш надад гар хүрэх нь бүү хэл хуруугаа хүргэж зүрхэлсэнгүй. Эдүгээ тэд миний өмнө гандах болуузай хэмээх учир ийнхүү үйлдэж эс зүрхэлнэм, Бурханы “Сүнс тийм хүчтэй байв; мөн энэ нь тэдэнд ийнхүү нөлөөлсөн буюу.

53 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн надад хэлэв: Гараа ах нарынхаа зүг дахин сунга, мөн тэд чиний өмнө

гандахгүй, харин би тэднийг цочрооно, мөн би бол Их Эзэн тэдний Бурхан мөнийг тэд мэдэж болохын тулд би үүнийг үйлдэх болно хэмээн Их Эзэн хэлэв.

54 Мөнхүү улиран тохиох дор би ах нарынхаа зүг гараа сунгавал, мөн тэд миний өмнө гандсангүй; харин Их Эзэн яг өөрийн хэлсэн тэрхүү үгийн дагуу тэднийг сэгсэрсэн буюу.

55 Мөн эдүгээ, тэд хэлэв: Бид Их Эзэн чамтай буйг гарцаагүй мэдлээ, учир нь биднийг сэгсэрсэн нь Их Эзэний хүч гэдгийг бид мэднэ. Мөн тэд миний өмнө унаж, мөн намайг “бишрэн шүтэхийг завдав, гэвч би тэдэнд зөвшөөрсөнгүй, хэлсэн нь: Би бол та нарын дүү, тийм ээ, бүр насан бага дүү чинь; иймийн тул, Их Эзэн Бурханаа бишрэн шүт, мөн эцэг эхээ дээдлэн хүндэл, Их Эзэн Бурхан тань та нарт өгөх тэрхүү нутагт та нарын “өдрүүд урт байж болохын тулд болой.

БҮЛЭГ 18

Усан онгоц дуусав—Иаков Иосеф хоёрын төрөлт дурдагдав—Уг бүлгийнхэн амлагдсан нутагт хүрэхээр хөдлөв—Ишмэлийн хөвгүүд мөн тэдний эхнэрүүд наргиан хийгээд эсэргүүцэлд нэгдэв—Нифай хүлэгдэж, мөн усан онгоц аймшигт хуй салхинд

50а Филип. 4:13;
1 Ниф. 3:7
51а Эхл. 6:14–16;

1 Ниф. 18:1.
52а су Ариун Сүнс.
55а Үйлс 14:11–15.

б Ег. 20:12;
Мозая 13:20.

буцаж туугдав—Нифай суллагдаж, мөн түүний залбирлаар шуурга зогсов—Уг хүмүүс амлагдсан нутагт хүрэв. Ойролцоогоор мээ 591–589 он.

Мөнхүү улиран тохиох дор тэд Их Эзэнийг бишрэн шүтэж, мөн надтай хамтран одов; мөн бид дүнз модыг нямбайлан урнаар дархлав. Мөн Их Эзэн усан онгоцны дүнз модыг ямар маягаар бэлтгэхийг цагаас цагт надад үзүүлж байсан бөлгөө.

2 Эдүгээ би, Нифай, дүнз модыг хүмүүсээр сургагдсан тэр маягаар бэлтгэсэнгүй, хүмүүсийн барьдаг тийм маягаар ч усан онгоцыг би бас барьсангүй; харин би Их Эзэн надад үзүүлсэн тэр маягаар барьсан билээ; иймийн тул, энэ нь хүмүүсийнхтэй адил байсангүй.

3 Мөн би, Нифай, байн байн ууланд гарч, мөн би Их Эзэнд дахин дахин “залбирсан бөлгөө; иймийн тул Их Эзэн надад агуу зүйлийг үзүүлэв.

4 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний үгийн дагуу усан онгоцыг би дуусгасны дараа, ах нар маань энэ нь сайн болсныг, мөн үүний ур хийц үлэмж сайн байсныг харсан бөлгөө; иймийн тул, тэд Их Эзэний өмнө өөрсдийгөө дахин “даруусгав.

5 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний дуу хоолой эцэгт минь ирж, биднийг босч мөн

усан онгоцонд очвол зохино хэмээв.

6 Мөнхүү улиран тохиох дор маргааш өдөр нь бид бүх зүйлийг, аглаг буйдаас ихээхэн жимс бас “хүнс, мөн арвин их бал, мөн Их Эзэн бидэнд зарлигласны дагуу хоол хүнс бэлтгэсний дараа, бид өөрсдийн бүх ачаа мөн үр тариаг, мөн бид насны эрэмбээр, авчирсан бүх зүйлээ өөрсөддөө авч усан онгоцонд очив; иймийн тул, бид бүгд эхнэр болон хүүхдүүдийнхээ хамт усан онгоцонд очсон бөлгөө.

7 Мөн эдүгээ, эцэг минь аглаг буйдад хоёр хөвгүүнтэй болсон байв; ахмад нь “Иаков, дүүмэд нь “Иосеф хэмээгдэх бөлгөө.

8 Мөнхүү улиран тохиох дор бидэнд зарлиг болсон тэр зүйлүүд мөн хоол бид бүгд хүнсээ өөрсөддөө авч, усан онгоцонд очсоны дараа, бид “тэнгист гарч, “амлагдсан нутгийг зүглэн салхинд туугдан одов.

9 Мөн бид олон хоногийн турш салхинд туугдсаны дараа, болгоогтун, ах нар маань бас Ишмэилийн хөвгүүд мөн түүнчлэн тэдний эхнэрүүд өөрсдийгөө зугаацуулж эхлэв, үүний хэрээр тэд бүжиглэж мөн дуулж, бас ихэд балмадыг ярьж эхлэв, тийм ээ, бүр тэд хэний хүчээр тэнд авчрагдсанаа мартсан байв; тийм ээ, тэд үлэмж балмад явдалдаа хөөрөн байв.

18 За су Залбирал.
б су Илчлэлт.
4а 1 Ниф. 16:5.

6а 1 Ниф. 17:2.
7а 2 Ниф. 2:1.
б 2 Ниф. 3:1.

8а 2 Ниф. 10:20.
б 1 Ниф. 2:20.
су Амлалтын нутаг.

10 Мөн би, Нифай, Их Эзэн бидэнд уурлаж, мөн алдсын маань улмаас биднийг цохъж тэгээд бид тэнгисийн гүнд үйх буюу хэмээн үлэмж айж эхлэв; иймийн тул, би, Нифай, тэдэнд ихэд буурь суурьтайгаар ярьж эхлэв; гэвч болгоогтун тэд надад “уурлаж, хэлсэн нь: Бид дүүгээ өөрсдийн захирагч байлгахгүй хэмээв.

11 Мөнхүү улиран тохиох дор Лемен Лемүел хоёр намайг барьж мөн олсоор хүлээд, мөн тэд надад ихэд хэрцгийгээр хандав; гэсэн хэдий ч ёсон бусыг үйлдэгчдийн талаар түүний ярьсан үг гүйцэлдэхийн тулд, Их Эзэн өөрийн хүчийг үзүүлэхээр үүнийг үйлдэхийг “тэвчсэн буюу.

12 Мөнхүү улиран тохиох дор тэд намайг хүлж үүний хэрээр би хөдөлж чадахаа больсны дараа, Их Эзэн бэлтгэж өгсөн мөнөөх “луужин ажиллахаа болив.

13 Иймийн тул, тэд усан онгоцыг хааш залахыг мэдсэнгүй, тэгтэл их салхи босох нь тэр, тийм ээ, агуу бөгөөд аймшигт хуй салхи, мөн бид усан дээгүүр гурав хоногийн турш “буцаан туугдав; мөн далайд живэх болуузай хэмээн үлэмж айж эхлэв; гэсэн хэдий ч, тэд намайг сулласангүй.

14 Мөн бид буцаж туугдсаны

дөрөв дэх өдөр, хуй салхи үлэмж ширүүн болж эхлэв.

15 Мөнхүү улиран тохиох дор бид бараг л далайн гүнд үйхийг шахав. Мөн бид дөрвөн өдрийн турш усан дээгүүр буцаж туугдсаны дараа, ах нар маань Бурханы шүүлт тэдний дээр байсныг, мөн тэд алдсаа наманчлахгүй аваас тэд эрсдэх ёстой гэдгийг сая “ойлгож эхлэв; иймийн тул, тэд надад ирж, мөн миний бугуйн дахь хүлгийг суллан авав, мөн болгоогтун миний гарын хоёр бугуй үлэмж хавдсан байв; мөн түүнчлэн миний хөлийн шагай ч маш их хавдаж, хөндүүрлэх нь туйлын бэрх байлаа.

16 Гэсэн хэдий ч, би Бурхандаа найдаж, мөн би түүнийг бүхэл өдрийн турш “магтан алдаршуулав; мөн би зовлон зүдгүүрүүдийнхээ учир Их Эзэний эсрэг бувтнасан нь үгүй билээ.

17 Эдүгээ миний эцэг, Лихай, тэдэнд мөн түүнчлэн “Ишмэилийн хөвгүүдэд олон зүйлийг хэлсэн байв; гэвч, болгоогтун, тэд миний төлөө ярьсан хэнийг боловч ихэд эсэргүүцэн сүрдүүлэв; мөн эцэг эх минь насанд дарагдан, мөн хүүхдүүдийнхээ улмаас уй гашуу болон шаналсны улмаас, дордож, тийм ээ, тэд бүр хэвтэрт оров.

18 Тэдний уй гашуу, их

10a 1 Ниф. 17:17–55.

б Эхл. 37:9–11;

1 Ниф. 16:37–38;

2 Ниф. 1:25–27.

11a Алма 14:11.

12a 1 Ниф. 16:10, 16, 26;

2 Ниф. 5:12;

Алма 37:38–47;

С ба Г 17:1.

13a Мозая 1:17.

15a Хил. 12:3.

16a Алма 36:28.

17a 1 Ниф. 7:4–20.

эмгэнэл, мөн ах нарын маань алдсын учир, тэд бүр энэ цагийг орхин одож Бурхантайгаа уулзахад ойрхон болсон байв; тийм ээ, тэдний буурал үс газар тавигдах болоод байв; тийм ээ, тэд бүр уйтгар гунигаа тээн усан булшинд орхигдоход ойрхон байлаа.

19 Мөн түүнчлэн Иаков Иосеф хоёр бага байж, халамж ихэд хэрэгтэй байснаас, эхийнхээ зовлон зүдгүүрүүдийн улмаас шаналж байв; мөн түүнчлэн “эхнэрийн минь асгаруулах нулимс мөн залбирлууд бас түүнчлэн миний хүүхдүүдийнх ч, ах нарын минь сэтгэлийг тэд намайг чөлөөлөхөөр болтол зөөллөсөнгүй.

20 Мөн тэднийг устгалаар сүрдүүлэх Бурханы хүчнээс өөр тэдний зүрх сэтгэлийг зөөллөх юм юухан ч байсангүй; иймийн тул, тэд бараг далайн гүнд үйх гэж буйгаа хараад тэд үйлдсэн зүйлийнхээ төлөө наманчилж, тэгээд намайг суллав.

21 Мөнхүү улиран тохиох дор тэд намайг сулласны дараа, болгоогтун, би луужинг авав, мөн энэ нь миний хүссэнээр ажиллаж байв. Мөнхүү улиран тохиох дор би Их Эзэнд залбирав; тийнхүү намайг залбирсны дараа салхи зогсож, мөн шуурга номхров, тэгээд ихэд нам тайван болов.

22 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, усан онгоцыг

удирдаж, бид амлагдсан нутгийг дахин чиглэв.

23 Мөнхүү улиран тохиох дор бид олон хоногийн турш хөвсний дараа бид “амлагдсан нутагт хүрч ирэв; мөн бид урагш газар дээр гарч, майхнуудаа босгов; тэгээд бид үүнийг амлагдсан нутаг гэж нэрлэсэн бөлгөө.

24 Мөнхүү улиран тохиох дор бид газар боловсруулж эхлэн, мөн бид үр тариагаа суулгаж эхлэв; тийм ээ, бид Иерусалим нутгаас авчирсан тэр бүх үрээ газарт суулгав. Мөнхүү улиран тохиох дор тэдгээр нь үлэмж сайн ургав; иймийн тул, бид элбэг дэлбэгээр адислагдав.

25 Мөнхүү улиран тохиох дор бид амлалтын нутагт, аглаг буйдад аялж байх зуур ойн бүх төрлийн араатан амьтад, үхэр болон шар аль аль нь, мөн илжиг ба морь, мөн ямаа ба зэрлэг ямаа, мөн бүх төрлийн зэрлэг амьтад, хүний хэрэгцээнд зориулагдсан байхыг олсон бөлгөө. Мөн бид алтны, бас мөнгөний, бас зэсийн хүдрийг бүх төрлөөр нь олов.

БҮЛЭГ 19

Нифай хүдрээс ялтсуудыг хийж мөн өөрийн хүмүүсийн түүхийг цэдэглэв— Лихай Иерусалимыг орхисон цагаас зургаан зуун жилийн тэртээ Израилын Бурхан ирэх болно— Түүний зүдгүүрүүд болон цовдлолын талаар

Нифай өгүүлэв—Их Эзэндээ эргэж ирэх хожмын өдрүүдийг хүртэл Иудейчүүд гадуурхагдаж бас тараагдах болно. Ойролцоо-гоор мээ 588–570 он.

Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн надад зарлигласан бөлгөө, иймийн тул би хүмүүсийнхээ цэдгийг сийлж болохын тулд ялтсуудыг хийсэн бөлгөө. Мөн өөрийн хийсэн “ялтсууд дээр би ^бэцгийнхээ цэдгийг, мөн түүнчлэн аглаг буйд дахь бидний аян, мөн эцгийнхээ бошиглолуудыг сийлбэрлэв; мөн түүнчлэн би тэдгээрийн дээр өөрийн бошиглолуудаас олныг сийлсэн билээ.

2 Мөн би тэдгээрийг хийж байх үед Их Эзэн эдгээр “ялтсуудыг хий хэмээн надад зарлиг болохыг мэдсэнгүй; иймийн тул, миний эцгийн цэдэг, мөн түүний өвөг дээдсийн удам судар, мөн аглаг буйд дахь бидний явдлуудын ихэнх нь миний ярьсан тэдгээр эхний ялтсууд дээр сийлбэрлэгдсэн билээ; иймийн тул, намайг эдгээр ^бялтсуудыг хийхээс урьд тохиолдсон тэдгээр зүйлүүд нь үнэхээр илүү нарийвчлалтайгаар эхний ялтсууд дээр дурдагдсан бөлгөө.

3 Мөн би эдгээр ялтсуудыг зарлигласнаар үйлдсэний дараа, би, Нифай, тохинуулал

болон бошиглолуудын илүү тодорхой болон эрхэм үнэт хэсгүүдийг эдгээр “ялтсууд дээр бичвэл зохино хэмээх зарлиг хүлээн авлаа; мөн бичигдсэн эдгээр зүйлүүд миний хүмүүст, уг нутгийг өвлөх тэдэнд заавар болж, мөн түүнчлэн бусад ^бмэргэн зорилгууд, Их Эзэний мэдэх тэр зорилгуудын улмаас хадгалагдах бөлгөө.

4 Иймийн тул, би, Нифай, дайнууд болон зөрчилдөөнүүд мөн миний хүмүүсийн устгалуудын шастирыг өгүүлнэ, өөрөөр хэлбэл илүү дэлгэрэнгүй шастирыг өгсөн нөгөө ялтсууд дээр цэдгийг бичиглэв. Мөн би үүнийг хийж бас намайг явсны дараа тэд юу хийвэл зохихыг өөрийн хүмүүст зарлиг болгов; мөн эдгээр ялтсууд үеэс үед, өөрөөр хэлбэл нэг бошиглогчоос нөгөөд дамжин Их Эзэний цаашдын зарлигуудыг хүртэл байх буюу.

5 Мөн би эдгээр ялтсуудыг “хийсэн тухай шастир хожим нь өгөгдөх болно; мөн тэгээд, болгоогтун, би ярьсныхаа дагуу үргэлжлүүлнэ; мөн бибээр үүнийг хийсний учир нь илүү эрхэм нандин зүйлүүд нь өөрийн хүмүүсийн мэдлэгийн тулд ^бхадгалагдаж болно гэснийх бөлгөө.

6 Гэсэн хэдий ч, би “эрхэм

19 1a су Ялтсууд.

б 1 Ниф. 1:16–17; 6:1–3.

2a 2 Ниф. 5:30.

б 1 Ниф. 9:1–5.

3a Иаков 1:1–4; 3:13–14;
4:1–4.

б 1 Ниф. 9:4–5;

Мор. үгс 1:7;

С ба Г 3:19–20;

10:1–51.

5a 2 Ниф. 5:28–33.

б су Судрууд—

Хадгалагдсан
судрууд.

6a Мормоны Номны
эхний хуудсыг үз.
су Ариун.

нандин гэж бодсоноос бусдыг ялтсууд дээр нэгээхнийг ч бичиглэх нь үгүй. Мөн эдүгээ, хэрэв би алдаа гаргасан ахул, бүр урьд цагийн тэд ч бас алдаа гаргасан бөлгөө; бусадтай адилтган өөрийгөө би зөвтгөхгүй, харин махбодид оршсоны дагуу өөрт буй ^бдутагдлаас өөрийгөө би зөвтгөнө.

7 Учир нь зарим хүмүүн махбодийн болон сүнсний аль алиных нь хувьд ихэд чухалчлан үнэлэх зүйлийг, бусад зарим нь “үл ойшоож мөн хөл дороо дэвслэх ажгуу. Тийм ээ, бүр Израилын туйлын Бурханыг ч хүмүүс хөл дороо ^бдэвслэх ажээ; би хэлнэ, хөл дороо дэвслэх гэхээс би өөр үгээр хэлье — тэд түүнийг үл ойшоож, мөн түүний зөвлөх дууг эс анхаарна.

8 Мөн болгоогтун тэнгэр элчийн үгсийн дагуу, миний эцэг Иерусалимыг орхисон цагаас “зургаан зуун жилийн тэртээ тэрээр ^ббирэх болно.

9 Мөн энэ дэлхийнхэн, алдсынхаа учир, гологдсон зүйл мэт түүнийг шүүх болно;

иймийн тул тэд түүнийг ташуурдахад, мөн тэрээр үүнийг тэвчинэ; мөн тэд түүнийг цохиход, мөн тэрээр үүнийг тэвчинэ. Тийм ээ, тэд түүнийг “нулимах бөлгөө, мөн хүмүүний үрсийн зүг хандах өөрийн өгөөмөр хайр мөн өөрийн хүлцэнгүй тэсвэрлэлийн учир тэрээр үүнийг тэвчих болно.

10 Мөн бидний эцэг өвгөдийн, Египетээс боолчлолоос “удирдагдан гаргагдсан, мөн түүнчлэн аглаг буйдад түүгээр хамгаалагдсан тэдний ^бБурхан, тийм ээ, Абрахамын, мөн Исаакийн ^бБурхан, мөн Иаковын Бурхан, ^вЗенокийн үгсийн дагуу ^ддээш өргөгдөхөөр, мөн Неюмийн үгсийн дагуу ^ецовдлогдохоор, мөн далайн арлуудад оршин суугч тэдэнд, ялангуяа Израилын ^еугсааныхан болох тэдэнд өгөгдөх түүний үхлийн тэмдэг болох гурав хоногийн ^жхаранхуйн талаар ярьсан ^зЗиносын үгсийн дагуу “хадан булшинд оршуулагдахаар тэнгэр элчийн үгсийн дагуу,

6б Морм. 8:13–17;
Ифер 12:23–28.

7а 2 Ниф. 33:2;
Иаков 4:14.

б су Эсэргүүцэл.

8а 1 Ниф. 10:4;
2 Ниф. 25:19.

б су Есүс Христ—
Есүс Христийн төрөлт болон нас баралтын тухай бошиглол.

9а Иса. 50:5–6;
Мат. 27:30.

10а Ег. 3:2–10; 6:6;
1 Ниф. 5:15;

С ба Г 136:22.

б 2 Ниф. 26:12;
Мозая 7:27; 27:30–31;
Алма 11:38–39;
3 Ниф. 11:14–15.

в Эхл. 32:9;
Мозая 7:19;
С ба Г 136:21.
су Иехова.

г Алма 33:15; 34:7;
Хил. 8:19–20;
3 Ниф. 10:15–16.
су Судрууд—
Алдагдсан судрууд;
Зенок.

д 3 Ниф. 27:14.

е 2 Ниф. 6:9;
Мозая 3:9.

су Цовдлуулалт.

ё 3 Ниф. 16:1–4.

ж 1 Ниф. 12:4–5;
Хил. 14:20, 27;
3 Ниф. 8:3, 19–23;
10:9.

з Иаков 6:1;
Хил. 15:11.
су Зенос.

и Мат. 27:60;
Лук 23:53;
2 Ниф. 25:13.

хүмүүний адилаар, ёсон бус хүмүүсийн гарт өөрийгөө "өгөх болно.

11 Учир нь бошиглогч тийн ярив: тэр өдөр Их Эзэн Бурхан Израилын бүх угсааны ханд заримд нь тэдний зөв шударгын учир тэрээр өөрийн дуу хоолойгоор тэдэнд агуу их баяр хөөр мөн аврал болж, мөн бусад заримд нь түүний хүч болох "тэнгэрийн дуу мөн аянга цахилгаан, шуурга, түймэр, мөн утаа, мөн ^бхаранхуйлах манан, мөн ^вгазар нээгдэн хагарах, мөн өргөгдөн зөөгдөх ^гуулсаар ^дзочлох нь гарцаагүй болой.

12 Мөн эдгээр "бүх зүйл гарцаагүй ирнэ гэдгийг бошиглогч ^бЗинос хэлсэн билээ. Мөн газрын "хад чулуу хагарах ёстой; мөн газар дэлхийн ёолох дуунаас Бурханы Сүнсний нөлөөн дор, далайн арлын хаадын олон нь: Хорвоогийн Бурхан зовж байна хэмээн уулга алдах болно.

13 Мөн Иерусалимд байгч тэдэнд зориулан, бошиглогч хэлсэнчлэн, тэд бүх хүмүүсээр "цээрлүүлэгдэх болно, тэд Израилын Бурханыг ^бцовдолж, мөн зүрх сэтгэлээ өөр зүг хандуулж, тэмдгүүд болон гайхамшгуудаас, мөн

Израилын Бурханы суу билиг болон хүчийг эсэргүүцсэний учир бөлгөө.

14 Мөн тэд зүрх сэтгэлээ өөр зүг хандуулсны учир, бошиглогчийн хэлсэнчлэн, мөн Израилын Ариун Нэгэнийг "гадуурхсаны учир, тэд энэ бие махбодид орших үедээ хэсэн бэдэрч, мөн шийтгэгдэж, мөн ^бмуугаар хэлэгдэн бас "муугийн зүйр болон, мөн бүх үндэстний дунд үзэн ядагдах болно.

15 Гэсэн хэдий ч, бошиглогчийн хэлсэнчлэн тэд зүрх сэтгэлээ Израилын Ариун Нэгэний эсрэг өөр зүг "дахин хандуулахгүй тэрхүү өдөр ирэхэд, тэгээд тэрээр тэдний эцэг өвгөдтэй хийсэн ^бгэрээнүүдээ санах болно.

16 Тийм ээ, тэгээд тэрээр далайн "арлуудыг санах болно; тийм ээ, мөн бошиглогч Зиносын үгсийн дагуу Израилын угсааны бүх хүмүүсийг би энэ дэлхийн дөрвөн зүгээс ^бцуглуулах болно хэмээн Их Эзэн хэлэх ажгуу.

17 Тийм ээ, мөн бүх дэлхий Их Эзэний авралыг "үзэх болно хэмээн бошиглогч хэлсэнчлэн; бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс адислагдах болно.

10й су Цагаатгах,
Цагаатгал.

11а Хил. 14:20–27;

3 Ниф. 8:5–23.

б Лук 23:44–45;

3 Ниф. 8:19–20.

в 2 Ниф. 26:5.

г 3 Ниф. 8:10.

д 3 Ниф. 9:1–22;

С ба Г 5:16.

12а Хил. 14:20–28.

б Иаков 5:1.

в Мат. 27:51.

13а Лук 23:27–30.

б 2 Ниф. 10:3.

14а Иса. 53:3–6;

Мозая 14:3–6.

б су Иудейчүүд.

в Дэд хууль 28:37;

Хаад. дээд 9:7;

3 Ниф. 16:9.

15а 1 Ниф. 22:11–12.

б су Абрахамын Гэрээ.

16а 1 Ниф. 22:4;

2 Ниф. 10:21.

б Иса. 49:20–22.

су Израил—

Израилын

цугларалт.

17а Иса. 40:4–5.

18 Мөн би, Нифай, эдгээр зүйлийг өөрийн хүмүүст хандан бичиглэсэн болой, би тэднийг Их Эзэн өөрсдийн Гэтэлгэгчийг санахад ятган итгүүлж болох магад хэмээнэ.

19 Иймийн тул, хэрэв тэд “эдгээр зүйлийг олж авах аваас би Израилын бүх угсааныханд ярих буюу.

20 Учир нь болгоогтун, Иерусалим дахь тэдний төлөө өөрийгөө цуцтал, бүр үе мөчөө сульдтал оюун сэтгэлдээ догдолно би; учир нь Их Эзэн бүр хуучны бошиглогчдод үзүүлснийхээ нэгэн адил надад тэдний талаар үзүүлж нигүүлсэнгүй байгаагүй бол би ч түүнчлэн эрсдэх байсан биз ээ.

21 Мөн тэрээр хуучны “бошиглогчдод тэдний ^бталаар бүх зүйлийг үзүүлсэн нь гарцаагүй; мөн түүнчлэн тэрээр бидний талаар олонд үзүүлсэн билээ; иймийн тул, тэдгээр нь гуулин ялтсууд дээр бичиглэгдсэний учир бид тэдний талаар мэдэх нь зайлшгүй бөлгөө.

22 Эдүгээ улиран тохиох дор би, Нифай, эдгээр зүйлийг ах нартаа сургав; мөнхүү улиран тохиох дор урьд цагийн хүмүүсийн дундах, өөр нутгууд дахь Их Эзэний үйлүүдийн талаар тэд мэдэж болохын тулд гуулин “ялтсууд дээр

сийлэгдсэн байсан, олон зүйлийг би тэдэнд уншиж өгсөн бөлгөө.

23 Мөн би Мосегийн “номнуудад бичигдсэн байсан тэр олон зүйлийг тэдэнд уншиж өгсөн болой; гэвч би тэднийг Их Эзэн өөрсдийн Гэтэлгэгчид итгэхийг илүү бүрэн дүүрнээр ятгаж болно хэмээн би тэдэнд бошиглогч ^бИсаиагийн бичиглэснийг уншиж өгөв; учир нь энэ нь бидэнд эрдэм болон “тус байж болохын тулд би бүх судрыг өөрсөдтэйгөө ^вадилтгасан билээ.

24 Иймийн тул би тэдэнд хандан ярьж, өгүүлсэн нь: Израилын угсааны үлдэгдэл, хугарсан “мөчрүүд болох та нар бошиглогчийн үгсийг сонс; Израилын бүх угсаанд бичигдсэн бошиглогчдын үгсийг сонс, мөн та нарын тэднээс салгагдсан ах дүүсийнхээ нэгэн адил та нар найдлага агуулж болохын тулд тэдгээр үгсийг өөрсөдтэйгөө адилтган үз; учир нь иймэрхүү маягаар бошиглогч бичиглэсэн болой.

БҮЛЭГ 20

Их Эзэн өөрийн зорилгуудыг Израилд илчлэв—Израил зовлон зүдгүүрийн зууханд сонгогдож

19a Инос 1:16;
Морм. 5:12; 7:9–10.

21a Хаад. дэд 17:13;
Амос 3:7.
су Бошиглогч.
б 3 Ниф. 10:16–17.
22a 1 Ниф. 22:1.

23a Ег. 17:14;
1 Ниф. 5:11;
Мосе 1:40–41.
б 1 Ниф. 15:20;
2 Ниф. 25:4–6;
3 Ниф. 23:1.
в 2 Ниф. 4:15.

г су Судрууд—
Судруудын үнэ
цэнэ.
24a Эхл. 49:22–26;
1 Ниф. 15:12;
2 Ниф. 3:4–5.

*мөн Вавилоноос явах бөлгөө—
Исаиагийн 48-тай харьцуул.
Ойролцоогоор мээ 588–570 он.*

Сонсоцгоо мөн үүнийг анхаар, ай Иаковын угсаа, Израилын нэрээр нэрлэгдсэн, мөн Иудейн уснаас, өөрөөр хэлбэл “баптисмын уснаас гарч ирсэн та нар, Их Эзэний нэрээр тангараглах, мөн Израилын Бурханыг дурдах та нар, тийм хэдий ч тэд үнэнээр бус тангарагладаг бас зөв шударгаар ч бус болой.

2 Гэсэн хэдий ч, тэд өөрсдийгөө “ариун хотынхон гэж нэрлэдэг, гэвч тэд өөрсдөө Израилын Бурханд, Түмний Их Эзэн түүнд ^бтулгуурладаггүй; тийм ээ, Түмний Их Эзэн гэж түүний нэр болой.

3 Болгоогтун, би “урьдын зүйлийг эхлэлээс тунхагласан болой; мөн тэдгээр нь миний амнаас гарч, мөн би тэдгээрийг үзүүлсэн бөлгөө. Би тэдгээрийг гэнэтхэн үзүүлсэн билээ.

4 Мөн би үүнийг хийсэн учир нь би “та нарын гөжүүдийг, мөн та нарын хүзүү төмөр шөрмөс, мөн та харын магнай гуулин гэдгийг мэддэг байлаа.

5 Мөн би бүр эхлэлээс та нарт тунхагласаар ирсэн; энэ нь улиран тохиохоос урьд би та нарт тэдгээрийг үзүүлсэн;

мөн та нар—Миний “хиймэл шүтээн тэдгээрийг хийсэн, мөн миний зормол дүрс, мөн миний цутгамал дүрс тэдгээрийг зарлигласан гэж хэлэх болуузай хэмээн эмээсэн учир би тэдгээрийг үзүүлсэн юм.

6 Та нар энэ бүхнийг харж бас сонссон билээ; мөн та нар тэдгээрийг тунхаглахгүй гэж үү? Мөн би та нарт энэ цагийн шинэ зүйлийг, бүр далдлагдсан зүйлийг үзүүлсэн, мөн та нар тэдгээрийг мэдээгүй байсан буюу.

7 Тэдгээр нь эдүгээ бүтээгдсэн, мөн эхлэлээс бус, бүр та тэдгээрийг сонсоогүй тэр өдрөөс өмнө тэдгээр нь танд тунхаглагдсан, таныг—Болгоогтун би тэдгээрийг мэдсэн хэмээн хэлүүлэхгүйн тул буюу.

8 Тийм ээ, мөн та нар сонссон нь үгүй; тийм ээ, та нар мэдсэн нь үгүй; тийм ээ, тэр цагаас сонор тань нээгдээгүй байлаа; учир нь би та нарын ихэд итгэл эвдэн үйлдэхийг, мөн хэвлийд байхаасаа “зөрчигч хэмээн нэрлэгдсэнийг мэдсэн билээ.

9 Гэсэн хэдий ч, өөрийн “алдар суугийн төлөө би өөрийн хилэнг саатуулан, мөн өөрийгөө магтуулахын тулд би та нарыг тусгаарлахгүй тэвчинэ.

10 Учир нь болгоогтун, би

20 1а су Баптисм,
Баптисм хүртээх.
2а Иса. 52:1.
су Иерусалим.

б ө.х. Найдах.
3а Иса. 46:9–10.
4а ө.х. Израил.
5а су Хиймэл шүтээн.

8а Дуул. 58:3.
9а 1 Сам. 12:22;
Дуул. 23:3; 1
Иохан 2:12.

чамайг цэвэршүүлсэн, би чамайг “зовлон зүдгүүрийн зууханд сонгосон бөлгөө.

11 Миний өөрийн тусын тулд, тийм ээ, миний өөрийн тусын тулд би үүнийг хийнэ, учир нь миний “нэр гутаагдахыг би үл тэвчинэ, мөн би өөрийн алдар сууг өөр нэгэнд ^бөгөхгүй.

12 Намайг сонсоцгоо, ай Иаков, мөн миний дуудсан Израил, учир нь би бол тэр; би бол “эхнийх, мөн түүнчлэн би бол эцсийнх.

13 Миний мутар түүнчлэн дэлхийн суурийг “тавьсан юм, мөн миний баруун мутар тэнгэр хурмастыг асарласан бөлгөө. Би тэдэнд дуудан хэлж мөн тэд нэгдэн тогтох болно.

14 Та нар бүгд, чуулан цуглар, мөн сонс; хэн тэдний дунд байж эдгээр зүйлийг тэдэнд тунхагласан билээ? Их Эзэн түүнийг хайрласан; тийм ээ, мөн тэрээр тэднээр тунхаглуулсан өөрийн үгийг тэр “гүйцэлдүүлэх болно; мөн тэрээр ^бВавилонд өөрийн тааллаар үйлдэж, мөн түүний мутар халдейчууд дээр ирэх болно.

15 Түүнчлэн, Их Эзэн хэлнэ; би Их Эзэн, тийм ээ, би ярьсан; тийм ээ, би тунхаглуулахын тул түүнийг дуудсан

билээ, би түүнийг авчирсан, мөн тэрээр түүний замыг дэвжих болгоно.

16 Та нар надад ойртон ир; би “далдуур ярьсангүй; эхлэлээс, үүний тунхаглагдсан тэр цагаас би ярьсан; мөн Их Эзэн Бурхан, мөн түүний Сүнс намайг илгээсэн бөлгөө.

17 Мөн Их Эзэн, чиний “Гэтэлгэгч, Израилын Ариун Нэгэн хэлэв; би түүнийг илгээсэн, Их Эзэн чиний Бурхан тусыг олохыг чамд сургасан тэр, чиний явбал зохих тэр замаар чамайг ^будирдах тэрбээр, үүнийг үйлдсэн бөлгөө.

18 Ай чи миний “зарлигуудыг дуулсан болоосой— тэгсэн бол амар амгалан чинь гол мэт, мөн зөв шударга далайн давалгаа мэт байх сан буюу.

19 Чиний “үр удам түүнчлэн элсний ширхэг мэт байх сан; биеэс тасрах үр удам чинь далайн хайрга чулуу мэт байх сан; түүний нэр миний өмнө арилгагдах учиргүй, устгагдах ч үгүй болой.

20 Та нар Вавилоноос “яв, та нар халдейчуудаас зугт, та нар магтан дуулах дуугаар тунхагла, дэлхийн хязгаарт сонсго, үүнийг хэл; та нар: Их Эзэн өөрийн ^бзарц Иаковыг гэтэлгэв хэмээн хэлэх буюу.

10a су Дайсан.

11a Иер. 44:26.

б Иса. 42:8;

Моисе 4:1–4.

12a Илч. 1:17; 22:13.

су Альфа ба Омега;
Ууган.

13a Дуул. 102:25.

су Бүтээх, Бүтээл.

14a Хаад. дээд 8:56;

С ба Г 64:31; 76:3.

б су Бабел, Вавилон.

16a Иса. 45:19.

17a су Гэтэлгэгч.

б су; Илчлэлт.

Сүнсний удирдамж,

Сүнслэгээр

нөлөөлөгдөх

18a Ном. үгс 8:5.

19a Эхл. 22:15–19;

Хосеа 1:10.

20a Иер. 51:6;

С ба Г 133:5-14.

б Иса. 44:1–2, 21.

21 Мөн тэд “цангасан нь үгүй; тэрээр тэднийг цөлийг гаталган удирдсан; тэдний төлөө тэрээр ^бхаднаас ус үерлүүлсэн; тэрээр түүнчлэн хадыг хагалахад ус асгарсан билээ.

22 Мөн тэрээр энэ бүгдийг, мөн түүнчлэн илүү агуу хийсэн хэдий ч, Их Эзэн хэлсэнчлэн, ёсон бусыг үйлдэгчдэд “амар амгалан үгүй болой.

БҮЛЭГ 21

Мессиа харийнханд гэрэл байж, хоригдлуудыг чөлөөлөх болно— Израилынхан эцсийн өдрүүдэд хүчтэйгээр цуглуулагдах болно— Хаад тэдний асрагч эцэг байх болно— Исаиагийн 49-тэй харьцуул. Ойролцоогоор мээ 588–570 он.

Мөн үүнчлэн: Анхаарцгаа, Ай Израилын угсааныхан та нар, миний хүмүүсийн хоньчдын ёсон бус үйлүүдийн улмаас салгагдсан мөн зайлуулагдсан та нар бүгд; тийм ээ, салгагдсан, энгээр нэг тараагдсан миний хүмүүсийнх болох та нар бүгд, Ай Израилын угсаа. Анхаар, Ай “арлууд, хүмүүс ээ та нар ^бхолоос анхаарцгаа, намайг; Их Эзэн намайг хэвлийд байхад дуудсан билээ; эхийнхээ хэвлийд байхаас тэр миний нэрийг дурдсан бөлгөө.

2 Мөн тэрээр миний амыг хурц илд мэт болгосон; тэр гарынхаа сүүдэрт намайг халхалж, мөн намайг өнгөлсөн сум мэт болгосон; тэр саадагтаа намайг далдалсан;

3 Мөн тэр надад хэлэв: Чи бол миний “үйлчлэгч, Ай Израил, би бол алдар суу дуурсгуулах тэр буюу.

4 Тэгээд би хэлэв, би дэмий хөдөлмөрлөсөн, би хүчээ юунд ч үгүй дэмий зүйлд үрсэн; миний шүүлт Их Эзэнтэй хамт, мөн миний ажил миний Бурхантай хамт байгаа нь гарцаагүй буюу.

5 Мөн эдүгээ Их Эзэн хэлэв—хэвлийд байхаас нь Иаковыг түүнд буцааж авчрахын тулд өөрийн үйлчлэгч байхаар намайг “бүрдүүлсэн тэр— Израил цуглуулагдаагүй байгаа хэдий ч, гэсэн ч би Их Эзэний мэлмийд алдарших болно, мөн миний Бурхан миний хүч байх болно.

6 Мөн тэр хэлэв: Иаковын “овгуудыг тодруулахад, мөн Израилын хамгаалагдагсдыг сэргээхэд чи миний үйлчлэгч байх нь амархан зүйл. Би түүнчлэн дэлхийн хязгааруудад миний аврал нь чи байж болохын тулд, ^бхарийнханд “гэрэл болгон чамайг би өгөх болно.

7 Тийн Их Эзэн, Израилын Гэтэлгэгч, түүний Ариун Нэгэн, хүмүүнд гадуурхагдах

21a Иса. 41:17–20.
б Ег. 17:6; Тоол. 20:11;
1 Ниф. 17:29;
2 Ниф. 25:20.
22a су Амар амгалан.
21 1a 1 Ниф. 22:4;

2 Ниф. 10:20–22.
б С ба Г 1:1.
3a Лев. 25:55; Иса. 41:8;
С ба Г 93:45–46.
5a Иса. 44:24.
6a су Израил—

Израилын арванхоёр овог.
б 3 Ниф. 21:11.
в С ба Г 103:8–10;
Абр. 2:10–11.

түүнд, үндэстнүүдэд жигшигдэх түүнд, захирагчдын үйлчлэгчид: үнэнч Их Эзэний учир, хаад хараад бас босох болно, хунтайжууд түүнчлэн бишрэн шүтэх болно хэмээн хэлэв.

8 Тийн Их Эзэн хэлэв: Тохиромжтой цагт би та нарыг сонссон, Ай далайн арлууд, мөн авралын өдөр би та нарт тусалсан билээ; мөн би чамайг хамгаалж, мөн хүмүүсийн гэрээ болгон “өөрийн үйлчлэгчийг та нарт өгөх, дэлхийг тогтоох, эзэнгүй өвүүдийг өвлүүлэхийн тулд бөлгөө.

9 Та нар “хоригдлуудад: Урагш од;” харанхуйд суугчдад: Өөрсдийгөө үзүүл хэмээн хэлж болохын тулд бөлгөө. Тэд замуудаараа идэшлэх болно, мөн тэдний “бэлчээр бүхий л өндөр газруудад байх болно.

10 Тэд өлсөхгүй бас цангах ч үгүй, мөн халуунд бас наранд цохиулахгүй; учир нь тэдний дээр нигүүлслийг хайрлах тэрээр тэднийг удирдах болно, бүр тэрээр усны ундаргаар тэднийг дагуулах болно.

11 Мөн би өөрийн бүх уулсыг зам болгож, мөн миний “их хөлийн замууд өргөмжлөгдөх болно.

12 Мөн тэгээд, Ай Израилын угсааныхан, болгоогтун, “эдгээр нь холоос ирэх болно;

мөн үз, эдгээр нь умардаас мөн өрнөдөөс; мөн эдгээр нь Синимийн нутгаас ирэх болно.

13 “ Дуул, Ай тэнгэр; мөн баяс, Ай дэлхий; учир нь дорнодод байгчдын хөл тогтоогдох болой; мөн дуулцгаа, Ай уулс; учир нь тэд дахин нэгээхэн ч цохигдохгүй; учир нь Их Эзэн өөрийн хүмүүсийг тайтгаруулж мөн өөрийн зовж зүдрэгсдийн дээр нигүүлслийг хайрлах болно.

14 Гэвч, болгоогтун, Сионийн хэлдэг: Их Эзэн намайг орхисон, мөн миний Их Эзэн намайг мартсан гэдэг—гэвч тэрээр тэгээгүй гэдгээ өөрөө үзүүлэх болно.

15 Учир нь “бүсгүй хүн хөхүүл хүүхдээ мартаж, хэвлийнээсээ унасан хүүгээ тэр өрөвдөн хайрлахгүй байж чадна гэж үү? Тийм ээ, тэд “мартаж болох юм, гэвч би чамайг мартаха нь үгүй, Ай Израилын угсаа.

16 Болгоогтун, би та нарыг гарынхаа “алган дээр сийлсэн; таны хананууд миний өмнө үргэлж байх бөлгөө.

17 Та нарын хүүхдүүд та нарыг устгагчдын эсрэг яарах болно; мөн чамайг “балгас болгосон тэд чамаас явах болно.

18 Нүдээ өргөн хараа бэлчээж мөн болгоогтун; эдгээр

8а 2 Ниф. 3:6–15;
3 Ниф. 21:8–11;
Морм. 8:16, 25.

9а су Нас барагсдын аврал.

б 2 Ниф. 3:5.

в Езек. 34:14.
11а Иса. 62:10;
С ба Г 133:23–32.

12а Иса. 43:5–6.

13а Иса. 44:23.

15а су Эмэгтэйхун,

Эмэгтэйчүүд.

б Иса. 41:17;

Алма 46:8;

С ба Г 61:36.

16а Зех. 13:6.

17а 3 Ниф. 21:12–20.

бүгд өөрсдөө нэгдэн “цугларч, мөн тэд чамд ирэх болно. Мөн би амьдын адил, Их Эзэн хэлдэг, чи тэр бүгдээр өөрийгөө хувцаслаж, гоёж чимэх мэтээр, мөн тэднийг агуулж бүр хуримын бэр мэт байх нь гарцаагүй бөлгөө.

19 Учир нь, та нарын балгас мөн чиний эзгүйрсэн газрууд, мөн устгалын нутаг, бүр эдүгээ оршин суугчдад дэндүү давчуухан байх болно; мөн чамайг залгисан тэд алс хол байх болно.

20 Чи эхнийхийгээ алдсаны дараа, чиний төрүүлэх хүүхдүүд, чихэнд чинь дахин: Уг газар надад дэндүү “давчуу байна; миний оршиж болох тэр газрыг надад өг хэмээн хэлэх болно.

21 Тэгээд “чи өөрийн зүрхэндээ: Эдний эцэг нь хэн байсан билээ, харсаар би хүүхдүүдээ алдсан мөн ^бхаягдмал, олзлогдмол, мөн нааш цааш нүүдэллэгч байсан бус уу? Мөн хэн эднийг өсгөн хүмүүжүүлэв? Болгоогтун, би ганцаар орхигдсон байсан, эд тэд хаана байсан бэ? хэмээн хэлэх бөлгөө.

22 Их Эзэн Бурхан тийн хэлэв: Болгоогтун, би мутраа “харийнханд өргөх болно, мөн хүмүүст өөрийн ^бдалбааг өргөнө; мөн тэд чиний хөвгүүдийг ^бгар дээрээ авчрах

болно, мөн чиний охид тэдний мөрөн дээр зөөгдөх болно.

23 Мөн “хаад та нарын ^басрагч эцэг, мөн тэдний хатад та нарын асрагч эх болно; тэд нүүрээ газарт хандуулан та нарт доош бөхийж, мөн та нарын хөлийн тоосыг долоох болно; мөн би бол Их Эзэн гэдгийг та нар мэдэх болно; учир нь намайг “хүлээх тэд ичихгүй байх болно.

24 Учир нь, чадалтай нэгний олз булаагдан авагдаж, эсвэл “хууль ёсоор боолчлогдсон тэд чөлөөлөгдөх үү?

25 Харин Их Эзэн тийн хэлэв, бүр хүчтэй нэгэнд олзлогдогсод ч авагдах болно, мөн аймшигт нэгний идэш чөлөөлөгдөх болно; учир нь чамтай тэрслэгч түүнтэй би ч бас тэрслэх болно, мөн би хүүхдүүдийг чинь аврах болно.

26 Мөн өөрсдийнх нь биесээр чамд дарамт бологч тэднийг би “тэжээх болно; тэд амтат дарсанд лугаа адил цусандаа согтох болно; мөн би, Их Эзэн, чиний Аврагч мөн чиний Гэтэлгэгч, Иаковын ^бХүчит Нэгэн гэдгийг бүх маханбодь ^бмэдэх болно.

БҮЛЭГ 22

Израил газар дэлхийн гадаргуу-

18a Мика 4:11–13.

20a ЭСВЭЛ Давчуу, эсвэл нарийн.

21a ө.х. Сион.

б Иса. 54:1; Гал. 4:27.

22a Иса. 66:18–20.

б Иса. 11:12; 18:3.

в 1 Ниф. 22:8;

2 Ниф. 10:8–9.

23a Иса. 60:16.

б 1 Ниф. 22:6.

в 2 Ниф. 6:13;

С ба Г 98:2;

133:10–11, 45.

24a 1 Ниф. 21:25.

26a 1 Ниф. 22:13–14.

б су Иехова.

в Мозая 11:22.

гаар нэг энгүй тараагдах болно— Харийнхан эцсийн өдрүүдэд сайн мэдээгээр Израилыг асран тэжээх болно— Израил цуглуулагдаж мөн аврагдах болно, мөн ёс бусыг үйлдэгчид талбайд үлдсэн сүрэл лугаа адил шатах болно— Чөтгөрийн хаант улс устгагдах болно, мөн Сатан хүлэгдэх болно. Ойролцоогоор мээ 588–570 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор би, Нифай, гуулин “ялтсууд дээр сийлэгдсэн эдгээр зүйлийг уншсаны дараа, миний ах нар надад ирж мөн надад хэлэв: Чиний уншсан эдгээр зүйлүүд ямар утгатай билээ? Болгоогтун, тэдгээр нь махбодиор биш харин сүнсээр улиран тохиох тэрхүү сүнслэг зүйлүүдийн дагуу ойлгогдох уу?

2 Мөн би, Нифай, тэдэнд хэлсэн нь: Болгоогтун тэдгээр нь “Сүнсний дуу хоолойгоор бошиглогчдод ^билчлэгдсэн буюу; учир нь махан бодийн дагуу хүмүүний үрсийн дээр ирэх тэр бүх зүйлүүд Сүнсээр “бошиглогчдод мэдүүлэгддэг бөлгөө.

3 Иймийн тул, миний уншсан тэдгээр зүйлүүд “зуурдын болон сүнслэг аль алинд нь хамаарах зүйлүүд; учир нь энэхүү Израилын угсаа эрт

орой нэгэн цагт, бүх дэлхийн гадаргуугаар мөн түүнчлэн бүх үндэстний дунд ^бтараагдсан мэт харагдана.

4 Мөн болгоогтун, Иерусалим дахь тэдгээрийн мэдлэгээс аль хэдийнэ алдуурсан нь олон буй. Тийм ээ, бүх “овгуудын ихэнх хэсэг нь гадагш ^будирдагдсан байгаа; мөн тэд далайн ^аарлууд дээгүүр энд тэндгүй тараагдсан болой; мөн бид тэдний гадагш удирдагдсаныг мэдэхээс бус, бидний нэг нь ч тэдний хаана буйг үл мэднэ.

5 Мөн тэд гадагш удирдагдсанаас хойш, тэдний талаар, мөн түүнчлэн Израилын Ариун Нэгэний учир, хойшид тараагдах тэд бүхний талаар эдгээр зүйлс бошиглогдсон буй; учир нь тэд түүний эсрэг зүрхээ хатууруулах болно; иймийн тул, тэд бүх үндэстний дунд тараагдах болно мөн бүх хүмүүсээр “үзэн ядагдах болно.

6 Гэсэн хэдий ч, тэд “харийнханаар ^басруулж, мөн Их Эзэн мутраа харийнханы дээр өргөж мөн тэднийг далбаа болгон өргөж, мөн тэдний “хүүхдүүд тэдний гарт зөөгдөж, мөн тэдний охид тэдний мөрөн дээр зөөгдсөний дараа, эдгээр яригдсан зүйлүүд бол зуурдынх гэдгийг болгоогтун;

22 1а 1 Ниф. 19:22;

2 Ниф. 4:2.

2а су Ариун Сүнс.

б 2 Петр 1:19–21.

в су Бошиглох,
Бошиглол.

3а С ба Г 29:31–34.

б 1 Ниф. 10:12–14;

2 Ниф. 25:14–16.

су Израил—

Израилын

Тараагдалт.

4а су Израил—

Израилын

алдагдсан арван

овог.

б 2 Ниф. 10:22.

в 1 Ниф. 21:1;

2 Ниф. 10:8, 20.

5а 1 Ниф. 19:14.

6а су Харийнхан.

б 1 Ниф. 21:23.

в 1 Ниф. 15:13.

учир нь бидний өвөг дээдэстэй Их Эзэний хийсэн гэрээнүүд ийм буюу; мөн энэ нь ирэх өдрүүдэд биднийг, мөн түүнчлэн Израилын угсааны бидний бүх ах дүүсийг илэрхийлэх бөлгөө.

7 Мөн бүх Израилын угсаа бусниулагдан мөн тараагдсаны дараа, Их Эзэн Бурхан хүчирхэг үндэстнийг “харийнханы дунд босгох цаг ирэх болно, тийм ээ, бүр энэ нутгийн гадаргуу дээр; мөн тэдгээр бидний үр удам ^бтараагдах болно.

8 Мөн бидний үр удам тараагдсаны дараа Их Эзэн Бурхан “харийнханы дунд бидний үр удамд агуу ^бүнэтэй болох ^агайхамшигт ажлыг хийхээр зорих болно; иймийн тул, энэ нь тэд харийнханаар асруулж мөн тэдний гарт мөн тэдний мөрөн дээр зөөгдөхтэй адилтгагдах буюу.

9 Мөн түүнчлэн энэ нь харийнханд “үнэтэй байх болно; мөн зөвхөн харийнханд ч биш харин ^ббүх Израилын ^аугсаанд, Абрахамтай хийсэн тэнгэрийн Эцэгийн ^ггэрээнүүдийг мэдүүлэхийн учраас буюу, үүнд хэлсэнчлэн: Чиний

^дүр удмаар дэлхийн бүх улс ^аадислагдах болно.

10 Мөн ах нар минь, тэрээр мутраа үндэстнүүдийн нүдэнд “харуулахгүй аваас газар дэлхийн бүх улс адислагдаж чадахгүйг та нар мэдээсэй хэмээнэ би.

11 Иймийн тул, Их Эзэн Бурхан өөрийн гэрээнүүд болон сайн мэдээг Израилын угсааны тэдэнд авчрахад мутраа бүх үндэстний нүдэнд харуулах болно.

12 Иймийн тул, тэрээр тэднийг боолчлолоос гарган дахин авчрах болно, мөн тэд өвлөж ирсэн нутгууддаа нэгдэн “цуглуулагдах болно; мөн тэд битүүлэг байдлаас мөн ^бхаранхуйгаас гаргагдах болно; мөн тэд “Их Эзэн бол тэдний ‘Аврагч мөн тэдний Гэтэлгэгч, Израилын ^дХүчит Нэгэн гэдгийг мэдэх болно.

13 Мөн бүх дэлхийн садар эм болох тэр, агуу хийгээд “жигшүүрт сүмийн цус, тэдний өөрсдийнх нь толгой дээр эргэх болно; учир нь тэд өөр хоорондоо ^бдайтах болно, мөн тэдний ^аөөрсдийнх нь гардахь сэлэм тэдний өөрсдийнх нь толгой дээр буух болно,

7a 3 Ниф. 20:27.

б 1 Ниф. 13:12–14;
2 Ниф. 1:11.

8a 2 Ниф. 10:10–11;
3 Ниф. 16:4–7;
Морм. 5:19.

б 1 Ниф. 15:13–18;
3 Ниф. 5:21–26; 21:7.

в Иса. 29:14;
1 Ниф. 14:7;
2 Ниф. 27:26.

су Сайн мэдээний

сэргээлт.

9a 1 Ниф. 14:1–5.

б 2 Ниф. 30:1–7.

в 2 Ниф. 29:13–14.

г Дэд хууль 4:31.

д су Абрахамын Гэрээ.

е Эхл. 12:2–3;

3 Ниф. 20:27;

Абр. 2:9–11.

10a Иса. 52:10.

12a су Израил—
Израилын

цугларалт.

б су Сүнсний
харанхуй.

в 2 Ниф. 6:10–11.

г су Аврагч.

д су Иехова.

13a су Чөтгөр—

чөтгөрийн сүм.

б 1 Ниф. 14:3, 15–17.

в 1 Ниф. 21:26.

мөн тэд өөрсдийнхөө цусанд өөрсдөө согтох болно.

14 Мөн таны эсрэг байлдах “үндэстэн бүр, Ай Израилын угсаа, нэг нь нөгөөгийнхөө эсрэг эргүүлэгдэх болно, мөн тэд Их Эзэний хүмүүсийг урхидахаар ухсан тэр нүхэндээ өөрсдөө ^бунах болно. Мөн Сионы эсрэг ^атулалдах тэд бүгд устгагдах болно, мөн Их Эзэний зөв замыг гажуудуулсан тэр, агуу садар эм, тийм ээ, тэр агуу хийгээд жигшүүрт сүм ‘газар шурган унаж мөн үүний уналт агуу байх болно.

15 Учир нь болгоогтун, Сатан хүмүүний үрсийн зүрхийг давах хүчийг дахин эзэмшихгүй байх тэр цаг удахгүй ирнэ; учир нь бүх бардам болоод ёс бусаар үйлдэгч хэн боловч “талбайд үлдсэн сүрэл лугаа адил болох өдөр удахгүй ирнэ; мөн тэд ^бшатаагдах ёстой өдөр ч удахгүй ирнэ хэмээн бошиглогч хэлдэг.

16 Өөрөөр хэлбэл хүмүүний бүх үрсийн дээр Бурханы “хилэгнэл тэр чигээрээ цутгагдах цаг удахгүй ирнэ; учир нь ёсон бусыг үйлдэгчид зөв шударгыг үйлдэгчдийг устгахыг тэрээр үл тэвчих ажгуу.

17 Иймийн тул, дайснуудыг нь бүр түймрээр устгах хэдий ч зөв шударгыг үйлдэгчид

хамгаалагдах бөгөөд түүний хилэгнэл тэр чигээрээ тэрчлэн ирэх байлаа ч тэрээр “зөв шударгыг үйлдэгчдийг өөрийн хүчээр ^бхамгаалах болно. Иймийн тул, зөв шударгыг үйлдэгчид айхын хэрэггүй; учир нь бошиглогчийн хэлсэнчлэн, бүр тэрчлэн түймрээр ч гэсэн тэд аврагдах болно.

18 Болгоогтун, ах дүү нар минь, би та нарт эдгээр зүйлүүд удахгүй ирэх ёстойг хэлнэ; тийм ээ, бүр цус, мөн түймэр, мөн хөшиглөх утаа ирэх ёстой; мөн энэ нь дэлхийн гадаргууд байх нь зайлшгүй; мөн хэрэв хүмүүн Израилын Ариун Нэгэний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулах аваас энэ нь үүнчлэн тэдэнд махан бодийн дагуу ирэх буюу.

19 Учрыг болгоогтун, зөв шударгыг үйлдэгчид эрсдэхгүй; өөрөөр хэлбэл Сионы эсрэг тулалдах тэд бүгд тусгаарлагдах цаг гарцаагүй ирэх ёстой.

20 Мосегийн ярьсан үгсийн биелэл болгон өөрийн хүмүүст замыг Их Эзэн бэлтгэх нь гарцаагүй, тэрээр хэлрүүн: “Бошиглогчийг Их Эзэн та нарын Бурхан та нарт, надад тодруулсны адил, тодруулах ажгуу; түүний та нарт хэлэх

14a Лук 21:10.

б Иса. 60:12;

1 Ниф. 14:3;

С ба Г 109:25.

в 2 Ниф. 10:13; 27:3.

г Иса. 25:12.

15a Иса. 5:23–24;

Нахум 1:10;

Малах. 4:1;

2 Ниф. 15:24;

26:4–6;

С ба Г 64:23–24;

133:64.

б Дуул. 21:9;

3 Ниф. 25:1;

С ба Г 29:9.

су Дэлхий—дэлхийн цэвэршилт.

16a 1 Ниф. 14:17.

17a 1 Ниф. 17:33–40.

б 2 Ниф. 30:10;

Моце 7:61.

20a Иохан 4:19; 7:40.

юуг боловч бүх зүйлд түүнийг та нар сонсох болно. Мөнхүү улиран тохиох дор тэр бошиглогчийг сонсохгүй хэн боловч бүгд, хүмүүсийн дундаас ^бтусгаарлагдах болно хэмээсэн бөлгөө.

21 Мөн эдүгээ би, Нифай, Мосегийн ярьсан тэр “бошиглогч нь Израилын Ариун Нэгэн байсныг та нарт тунхаглана; иймийн тул, тэрбээр ^бшүүлтийг зөв шударгаар гүйцэтгэнэ.

22 Мөн зөв шударгыг үйлдэгчид айх хэрэггүй, учир юун хэмээвээс бусниулагдахгүй тэд бол тэд бөлгөө. Гэвч чөтгөрийн хаант улс, хүмүүний үрсийн дунд босгогдох тэр, маханбодид орших тэдний дунд байгуулагдах хаант улс—

23 Өөрөөр хэлбэл баяжиж хөлжихөөр баригдсан, мөн маханбодийг давах хүчийг олохоор баригдсан тэд бүгд, мөн дэлхийнхний нүдэнд “алдрыг олохоор баригдсан тэд, мөн биеийн шуналыг, мөн дэлхийн зүйлийг, мөн бүх төрлийн алдсыг үйлдэхийг эрэлхийлдэг тэд, тэдгээр бүх ^бсүмүүд; тийм ээ, чухамдаа, чөтгөрийн хаант улсад харьяалагдах тэд бүгд айж, мөн чичирч, мөн ^ссалгалах

хэрэгтэй тэр цаг удахгүй ирэх болно; тэд бол шороо тоос мэт дорд үзэгдэх ёстой тэд буюу; тэд бол талбайд үлдсэн сүрэл лугаа адил “үрэгдэх ёстой тэд болой; мөн энэ нь бошиглогчийн үгсийн дагуу буюу.

24 Мөн зөв шударгыг үйлдэгчид пүнзэнд байх “тугалууд лугаа адил хөтлөгдөх ёстой, мөн Израилын Ариун Нэгэн хүч, мөн чадал, мөн агуу алдар суугаар эзэмшилдээ хаанчлах ёстой, тэрхүү цаг хурдан ирнэ.

25 Мөн тэрээр дэлхийн дөрвөн зүгээс хүүхдүүдээ “цуглуулна; мөн тэрээр хонио тоолж, мөн тэд түүнийг мэднэ; мөн нэг сүрэг мөн нэг ^бхоньчин байх болно; мөн тэрээр өөрийн хоньдыг тэжээж, мөн түүнд ^ббэлчээрийг тэд олох болно.

26 Мөн түүний хүмүүсийн зөв шударгын улмаас, “Сатан хүчгүй байна; иймийн тул, тэр ^болон жилийн хугацаанд чөлөөлөгдөж чадахгүй; учир нь тэр хүмүүсийн зүрхийг давах хүчгүй байна, учир нь тэд зөв шударгад оршиж, мөн Израилын Ариун Нэгэн “хаанчлах бөлгөө.

27 Мөн эдүгээ болгоогтун, би, Нифай, эдгээр бүх зүйл

206 С ба Г 133:63.

21a Дэд хууль 18:15, 18;

Үйлс 3:20–23;

1 Ниф. 10:4;

3 Ниф. 20:23.

б Дуул. 98:9;

Моце 6:57.

23a Лук 6:26; Алма 1:3.

б 1 Ниф. 14:10;

2 Ниф. 26:20.

су Санваараар

мэргэших.

в 2 Ниф. 28:19.

г 2 Ниф. 26:6.

24a Амос 6:4;

Малах. 4:2;

3 Ниф. 25:2.

25a су Израил—

Израилын

пугларалт.

б су Сайн Хоньчин.

в Дуул. 23.

26a Илч. 20:2;

Алма 48:17;

С ба Г 43:31; 45:55;

88:110; 101:28.

су Чөтгөр.

б Иаков 5:76.

в су Мянган Жил.

маханбодийн дагуу ирэх ёстойг та нарт хэлж байна.

28 Гэвч болгоогтун, бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүс хэрэв энэ нь түүнчлэн байж тэд “наманчлах аваас Израилын Ариун Нэгэнд аюулгүйгээр орших болно.

29 Мөн эдүгээ би, Нифай, төгсгөл болгоё; учир нь би эдгээр зүйлүүдийн талаар одоохондоо цааш ярьж эс зүрхлэх авай.

30 Иймийн тул, ах нар минь, би та нарыг гуулин “ялтсууд

дээр бичигдсэн зүйлүүд үнэн гэдгийг анхаарч үзэхийг хүсэж байна; мөн тэдгээр нь Бурханы зарлигуудад хүмүүн дуулгавартай байх ёстойг гэрчилдэг билээ.

31 Иймийн тул, зөвхөн миний эцэг бид хоёр л гэрчилж, мөн түүнчлэн тэдгээрийг заасан юм гэж та нар бодох хэрэггүй. Иймийн тул, хэрэв та нар “зарлигуудад дуулгавартай байж, мөн эцсийг хүртэл тэвчвээс, та нар эцсийн өдөр аврагдах болно. Мөн энэ нь ийм болой. Амен.

НИФАЙН ХОЁР ДАХЬ НОМ

Лихайн үхлийн тухай цэдэг оршвой. Нифайн ах нар түүнийг Лэсэргүүцэв. Их Эзэн Нифайд аглаг буйд тийш одохыг сануулан зөвлөв. Түүний аглаг буйд дахь аян мөн цаашдын үргэлжлэл оршвой.

БҮЛЭГ 1

Лихай эрх чөлөөт нутгийн талаар бошиглов—Хэрэв тэд Израилын Ариун Нэгэнийг эсэргүүцэх аваас түүний үр удам тараагдаж бас цохигдох болно—Зөв шударгын хуяг өмсөхийг тэрээр хөвгүүддээ ухуулав. Ойролцоогоор мээ 588–570 он.

МӨНХҮҮ эдүгээ улиран тохиох дор би, Нифай, ах нартаа сургамжлан байснаа төгсгөл болгосны дараа,

бидний “эцэг, Лихай, түүнчлэн тэдэнд олон зүйлийг ярьж, мөн тэднийг Иерусалим нутгаас авчирснаараа Их Эзэн тэдний төлөө ямар агуу зүйлийг үйлдсэнийг давтан өгүүлэв.

2 Мөн тэрээр тэдэнд хандан тэдний усан дээрх “эсэргүүцлийн, мөн далайд үйхээс тэдний амийг хэлтрүүлсэн Бурханы нигүүлслийн талаар яриу.

3 Мөн түүнчлэн тэрээр тэдэнд хандан тэдний эзэмшсэн

28a су Наманчлах,
Наманчлал;
Уучлах.
30a 2 Ниф. 4:2.

31a Мат. 19:17
су Бурханы
зарлигууд.
[2 НИФАЙ]

1a су Патриарх,
Патриархын.
2a 1 Ниф. 18:9–20.

тэр амлалтын нутгийн талаар — биднийг Иерусалим нутагаас зайлан гарахыг бидэнд сэргийлэн сануулснаараа Их Эзэн ямар нигүүлсэнгүй байсныг ярьсан билээ.

4 Тэрээр хэлэв, учир нь болгоогтун, “Иерусалим устгагдсаныг мэдүүлэх нэгэн үзэгдлийг би харав; мөн бид Иерусалимд үлдсэн аваас бид ч түүнчлэн эрсдэх байсан биз ээ.

5 Тэрээр хэлэв, гэвч, бид зовж зүдэрсэн ч, бид амлалтын “нутгийг эзэмшсэн, бүхий л нутгуудаас сонгомол тэр нутгийг бөлгөө; миний үр удамд өвлүүлэхээр Их Эзэн Бурхан надтай гэрээ хийсэн тэр нутгийг бөлгөө. Тийм ээ, Их Эзэн энэ нутгийг надад бас миний хүүхдүүдэд, мөн түүнчлэн Их Эзэний мутраар бусад орнуудаас удирдагдах тэд бүгдэд үүрд гэрээлэн өгсөн билээ.

6 Иймийн тул, би, Лихай, надад орших Сүнсний нөлөөний дагуу, Их Эзэний мутраар тэд авчрагдахаас бусдаар “хэн ч энэ нутагт ирэхгүйг бошиглон хэлж байна.

7 Иймийн тул, түүний авчрах түүнд энэ “нутаг ариулан адислагдсан буюу. Мөн хэрэв энэ нь үүнчлэн байж тэд түүний өгсөн зарлигуудын

дагуу түүнд үйлчлэх аваас, энэ нь тэдэнд эрх чөлөөний нутаг байх болно; иймийн тул, тэд хэзээ ч боолчлол дор авчрагдахгүй; хэрэв үүнчлэн тохиовол энэ нь алдсуудын учир болой; учир нь хэрэв алдас ихээр оршвоос уг нутаг тэдний хувьд зүүхэгдэнэ, гэвч зөв шударгыг үйлдэгчдэд энэ нь үүрд адислагдах болно.

8 Мөн болгоогтун, энэ нутаг бусад зарим үндэстнүүдэд хараахан мэдэгдэхгүйгээр хадгалагдах нь мэргэн ухаан болой; учир нь болгоогтун, олон үндэстэн уг нутгийг хөндлөн гулд туучсан аваас, өвлөгдөх газаргүй байх сан билээ.

9 Иймийн тул, Их Эзэн, Бурхан Иерусалим нутгаас авчрах тэд түүний зарлигуудыг дагахын “хэрээр, тэд энэ нутгийн гадаргуу дээр дэгжих болно; мөн тэд энэ нутгийг өөрсдөдөө эзэмшиж болохын тулд тэд бусад бүх үндэстнээс хамгаалах болно гэдэг амлалтыг Лихай, би олж авсан билээ. Мөн хэрэв тэд түүний зарлигуудыг дагаваас тэд энэ нутгийн гадаргуу дээр адислагдаж, мөн тэднийг гоочлох нэгээхэн ч, бас тэдний өвлөх нутгийг булаан авах хэн ч байхгүй байх болно; мөн тэд үүрд аюулгүй орших болно.

4а Хаад. дэд 24:14–15;

Иер. 44:2;

1 Ниф. 1:4;

Хил. 8:20.

б су Үзэгдэл.

в Алма 9:22.

5а су Амлалтын нутаг.

б Ифер 2:9–10.

в су Гэрээ.

6а 2 Ниф. 10:22.

7а Мозая 29:32;

Алма 46:10, 20.

б 2 Ниф. 10:11.

су Эрх чөлөө.

в Алма 45:10–14, 16;

Морм. 1:17;

Ифер 2:8–12.

9а 2 Ниф. 4:4;

Алма 9:13.

б Дэд хууль 29:9.

в су Дуулгавартай

байх, Дуулгавартай,

Дуулгавартай дагах.

10 Гэвч болгоогтун, газар дэлхийн мөн бүх хүмүүний бүтээгдсэн мэдлэгийг эзэмшиж; дэлхий бүтээгдсэнээс хойших Их Эзэний агуу хийгээд гайхамшигт ажлуудыг мэдэж; итгэлээр бүх зүйлийг үйлдэх хүч тэдэнд өгөгдсөи юм; мөн бүх зарлигууд эхлэлээс өгөгдөх болно, мөн түүний хэмжээлшгүй сайн чанараар энэ эрхэм сайхан амлалтын нутагт авчрагдах агуу адислалуудыг Их Эзэний мутраас хүлээн авсныхаа дараа тэд итгэлгүйдээ бууран доройтох цаг нь ирэхэд — болгоогтун, би хэлнэ, хэрэв тэд үнэн “Мессиа, тэдний Гэтэлгэгч, мөн тэдний Бурхан, Израилын Ариун Нэгэнийг эсэргүүцэх өдөр ирэх аваас, болгоогтун, түүний шударга шүүлтүүд тэдний дээр ирэх ажгуу.

11 Тийм ээ, тэрээр тэдний дээр “бусад үндэстнүүд болох тэднийг авчрах болно, мөн тэрээр тэдэнд хүчийг өгч, мөн тэрээр тэднээс эзэмшил газруудыг нь салган авч, мөн тэрээр тэднийг ^бтараагдсан бас бут цохигдсон байлгах болно.

12 Тийм ээ, нэг үе нөгөөгөө халахад “цус урсан, мөн агуу цээрлэлүүд тэдний дунд байх болно; иймийн тул, хөвгүүд

минь, та нарыг санаасай хэмээнэ би; тийм ээ, та нарыг миний үгсийг анхаараасай хэмээнэ би.

13 Ай та нар сэрээсэй; гүн нойрноос сэрээсэй; тийм ээ, бүр “тамын нойрноос, тэгээд та нар хүлэгдсэн тэр аймшигт ^бгинжээ сэгсрэн зайлуулаасай хэмээнэ, зовлон гамшгийн мөнхийн ^аангалд тэднийг доош олзлон хүргэхийн тулд хүмүүний үрсийг хүлэх тэр гинжийг буюу.

14 Сэрэгтүн! Тэгээд газар шорооноос бос, мөн үе мөчүүдийг нь, тэндээс нэгээхэн ч аянчин буцаж ирж чадахгүй тэрхүү хүйтэн бас чимээгүй “булшинд та нарыг удахгүй хэвтүүлэх ёстой, салгалан чичрэх ^бэцгийн үгсийг сонс; дахиад хэдхэн өдөр, тэгээд би энэ дэлхийн “жамаар явна.

15 Гэвч болгоогтун, Их Эзэн бодгалийг минь тамаас “гэтэлгэсэн; би түүний алдар сууг болгоож, мөн би түүний ^бхайрын ^амутраар мөнхөд хүрээлүүлсэн буюу.

16 Мөн та нар Их Эзэний “дүрэм болон тогтоолуудыг мөрдөхийг санаасай хэмээн хүснэм би; болгоогтун, энэ нь эхнээсээ бодгалийн минь зовнил байсан бөлгөө.

17 Миний зүрх сэтгэл цагаас цагт харамсалдаа хүндрэн

10а су Мессиа.

11а 1 Ниф. 13:12–20;
Морм. 5:19–20.

б 1 Ниф. 22:7.

12а Морм. 1:11–19; 4:11.

13а су Там.

б Алма 12:9–11.

в 1 Ниф. 15:28–30;

Хил. 3:29–30.

14а су Биеийн үхэл.

б су Эцэг эх.

в Иош. 23:14.

15а Алма 36:28.

су Цагаатгах,

Цагаатгал.

б Ром 8:39.

су Хайр.

в Иаков 6:5;

Алма 5:33;

3 Ниф. 9:14.

16а Дэд хууль 4:5–8;

2 Ниф. 5:10–11.

байв, та нарын зүрх сэтгэл хатуугийн учир Их Эзэн та нарын Бурхан, “хилэгнэлээ тэр чигээр нь та нарын дээр гарган та нарыг үүрд ^бзайлуулж бас устгах буйза;

18 Эсвээс, “олон үеийн турш зүхэл та нар дээр ирэх болно; мөн та нар илдээр, мөн өлсгөлөн, бас үзэн ядалтаар дайлагдаж мөн ^бчөтгөрийн таалал хийгээд боолчлолын дагуу удирдагдах бий хэмээн эмээхийн учир бөлгөө.

19 Ай хөвгүүд минь, эдгээр зүйлүүд та нарын дээр ирэхгүй байж болно, харин та нар Их Эзэний сонгомол мөн “таалалт хүмүүс байгаасай. Гэвч болгоогтун, түүний тааллаар бүтэх болтугай; учир нь түүний ^бзамууд үүрд зөв шударга болой.

20 Мөн тэрээр хэлсэн байдаг: та нар миний “зарлигуудыг дагахын ^бхэрээр та нар уг нутагт ^ддэгжих болно; харин та нар миний зарлигуудыг дагахгүй байхын хэрээр та нар миний дэргэдээс зайлуулагдах болно.

21 Мөн эдүгээ бодгаль минь та нарт баясаж болохын тулд, мөн миний зүрх та нарын учир баяртайгаар энэ дэлхийг орхиж болохын тулд, уйтгар гуниг болон харамслыг тээн доош булшинд аваачигдахгүй байж болохын

тулд, газар шорооноос бос, хөвгүүд минь, мөн “эр хүн шиг бай, бүх зүйлүүдэд нэгдэн хамтарч бас хатуу шийдэмгий нэг ^ббодол мөн нэг сэтгэлтэй бай, та нар боолчлолд орохгүй байж болохын тулд буюу.

22 Та нар зовлонт зүхлээр зүхэгдэхгүйн тулд; мөн түүнчлэн, та нар өөрсдийн дээр устгад, тийм ээ, сүнс болон биеийн аль алиных нь мөнхийн устгалд хүргэх, “шударга Бурханы харамсал дургүйцлийг хүртэхгүй байж болохын тулд буюу.

23 Сэрцгээ, хөвгүүд минь; зөв шударгын “хуягийг өмсөцгөө. Та нарыг хүлсэн тэр гинжийг сэгсрэн хая, тэгээд түнэр харанхуйгаас гарч ир, мөн газар шорооноос бос.

24 Мөн бид Иерусалимыг орхисон тэр цагаас, зарлигуудыг дагасан, мөн биднийг амлалтын нутагт авчрахад Бурханы мутарт зэмсэг болж байсан, түүний үзсэн нь дуурсгалт болох тэр дүүгийнхээ өөдөөс дахин бүү эсэргүүц; учир нь тэрбээр байгаагүй сэн бол бид аглаг буйдад “өлсөж эрсдэх байсан биз ээ; гэсэн хэдий ч та нар түүний амийг ^бавахаар эрэлхийлсэн; тийм ээ, мөн тэрээр та нарын улмаас их шаналлыг амссан билээ.

17a 2 Ниф. 5:21–24;
Алма 3:6–19.

б Мозая 12:8.

18a 1 Ниф. 12:20–23.

б су Чөтгөр.

19a су Сонгосон.

б Хосеа 14:9.

20a Лев. 26:3–14;

Иоел 2:23–26.

б Жером 1:9;

Мозая 1:6–7;

Алма 9:13–14.

в Дуул. 67:6;

Мозая 2:21–25.

21a 1 Сам. 4:9;

Хаад. дээд 2:2.

б Мосе 7:18.

22a С ба Г 3:4.

23a Ефес 6:11–17.

24a 1 Ниф. 16:32.

б 1 Ниф. 16:37.

25 Мөн тэрээр дахин зовох болов уу хэмээн би үлэмж айж бас дагжих нь та нарын улмаас бөлгөө, учир нь болгоогтун, тэрээр та нарыг давах хүч чадал болон “эрх мэдлийг эрэлхийллээ гэж та нар түүнийг буруутгасан билээ; гэвч тэрээр та нарыг давах хүч чадал мөн эрх мэдлийг ч эрэлхийлээгүй, харин тэрээр Бурханы алдар сууг, мөн та нарын өөрсдийн тань мөнхийн зол жаргалыг эрэлхийлснийг би мэднэ.

26 Мөн тэрээр та нарт илэн далангүй байсан учраас та нар бувтналдсан. Та нар тэрээр “хурц ширүүнийг хэрэглэсэн гэдэг; та нар түүнийг өөрсдөд тань ууртай хандсан гэдэг; гэвч болгоогтун, түүний хурц ширүүн нь түүнд байсан Бурханы үгний хүчний хурц ширүүн байсан болой; мөн та нарын уур гэх тэр нь, тэрээр тэвчиж үл чадан, та нарын алдсуудын талаар шударгаар нотолсон, Бурханд орших үнэний дагуух үнэн билээ.

27 Мөн Бурханы “хүч түүнтэй хамт байх ёстой нь зайлшгүй, бүр түүнийг тушаахад та нар дагах ёстой болтол буюу. Гэвч болгоогтун, энэ бол тэр биш, харин энэ бол түүнд оршсон, хамхиж чадахгүй болтол нь түүний ^бамыг нээж яриулах Их Эзэний ^сСүнс байсан билээ.

28 Мөн эдүгээ Лемен, хөв-

гүүн минь, мөн түүнчлэн Лемүел мөн Сам, мөн түүнчлэн Ишмэилийн хөвгүүд болох хөвгүүд минь, болгоогтун, хэрэв та нар Нифайн хэлснийг сонсох аваас та нар эрсдэхгүй болой. Мөн хэрэв та нар түүнийг анхааран сонсвоос би та нарт “адислалыг үлдээнэ, тийм ээ, бүр өөрийн эхний адислалыг буюу.

29 Гэвч хэрэв та нар түүнийг анхааран сонсохгүй бол би өөрийн “эхний адислалыг зайлуулан авна, тийм ээ, бүр өөрийн адислалыг, тэгээд энэ нь түүний дээр орших болно.

30 Мөн эдүгээ, Зорам, би чамд хэлнэ; Болгоогтун, та бол Лебений “зарц; гэсэн хэдий ч, чи Иерусалим нутгаас авчрагдсан, мөн чи бол миний хүү Нифайн үүрдийн үнэнч нөхөр гэдгийг би мэднэ.

31 Иймийн тул, чи итгэл хүлээснээс үр удам чинь түүнийхтэй “хамт энэ нутгийн гадаргуу дээр удаан хугацаанд дэгжин оршихоор тэд адислагдах болно; мөн тэдний дундах алдсаас өөр юу ч, тэднийг энэ нутгийн гадаргуу дээр үүрд дэвжин хөгжихөд хор хөнөөл үзүүлж мөн саад болж чадахгүй.

32 Иймийн тул, хэрэв та нар Их Эзэний зарлигуудыг дагах аваас, миний хүүгийн үр удамтай хамт чиний үр удмын аюулгүй байдлын тулд

25а Эхл. 37:9–11.
26а Сур. үгс 15:10;
1 Ниф. 16:2;
Моро. 9:4;

С ба Г 121:41–43.
27а 1 Ниф. 17:48.
б С ба Г 33:8.
в С ба Г 121:43.

28а су Өвлөх эрх.
29а Абр. 1:3.
30а 1 Ниф. 4:20, 35.
31а 2 Ниф. 5:6.

энэ нутгийг Их Эзэн ариулан адислах болой.

БҮЛЭГ 2

Гэтэлгэл Ариун Мессиагаар ирнэ— Сонгох эрх чөлөө нь оршин тогтнол болон дэвшил хөгжилд зайлшгүй— Адам хүмүүн байж болохын тулд унасан— Хүмүүн эрх чөлөө хийгээд мөнх амьдралыг сонгох эрхтэй. Ойролцоогоор мэв 588–570 он.

Мөн эдүгээ, Иаков, би чамд ярья: Чи бол аглаг буйд дахь миний зовлонт өдрүүдэд төрсөн “ууган хүү минь билээ. Мөн болгоогтун, чи хүүхэд ахуй үедээ ах нарынхаа балмадын учир их харамсал мөн зовлон үзсэн билээ.

2 Гэсэн хэдий ч, Иаков, аглаг буйдад төрсөн ууган хүү минь, чи Бурханы агуу ихийг мэдэх бөлгөө; мөн тэрээр зовлонгуудыг чинь чиний өсөлт хөгжлийн тул ариулан адислах болно.

3 Иймийн тул, бодгаль чинь адислагдсан болой, мөн чи ах Нифайнхаа хамт аюулгүй орших болно; мөн чиний өдрүүд өөрийн Бурханд үйлчлэхэд зориулагдсан байх болно. Иймийн тул, Гэтэлгэгчийнхээ зөв шударгын учир чибээр гэтэлгэгдсэнийг би мэднэ;

учир нь хүн төрөлхтөнд авралыг авчрахаар тэрээр цаг хугацааны бүрэн байдалд ирэхийг нь чи үзсэн билээ.

4 Мөн түүний алдар сууг залуу насандаа чи “үзсэн билээ; иймийн тул, тэрээр бүр өөрийн биеэр тохинуулах тэдний нэгэн адил адислагдсан чи; учир нь Сүнс өчигдөр, өнөөдөр бас үүрд нэгэн адил бөлгөө. Мөн хүмүүний уналтаас зам нь бэлтгэгдсэн, бас аврал бол ⁶өглөг буюу.

5 Мөн хүмүүн нь тэд сайныг муугаас “ялгаж мэдэхээр хангалттай зааварлагдсан буюу. Мөн хууль нь хүмүүнд өгөгдсөн болой. Мөн хуулийн дагуу ⁶зөвтгөгдөх маханбодь гэж үгүй; өөрөөр хэлбэл, хуулиар хүмүүн ⁶тусгаарлагдсан байна. Тийм ээ, зуурдын хуулиар тэд тусгаарлагдсан; мөн түүнчлэн, сүнслэг хуулиар тэд сайнаас хагацаж эрсдэн, мөн үүрд золгүй болох бөлгөө.

6 Иймийн тул Ариун “Мессиа, түүнд мөн түүгээр ⁶гэтэлгэл ирнэ; учир нь тэрээр “ач ивээл хийгээд үнэнээр дүүрэн буюу.

7 Болгоогтун, харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй хэний ч төлөө хуулийн шаардлагуудыг хангаж, тэрээр нүглийн “золиослол болгон өөрийгөө

2 1а 1 Ниф. 18:7.

4а 2 Ниф. 11:3;

Иаков 7:5.

б су Ач ивээл.

5а Моро. 7:16.

б Ром 3:20;

2 Ниф. 25:23;

Алма 42:12–16.

су Зөвтгөл, Зөвтгөх.

в 1 Ниф. 10:6;

2 Ниф. 9:6–38;

Алма 11:40–45;

12:16, 24; 42:6–11;

Хил. 14:15–18.

6а су Мессиа.

б 1 Ниф. 10:6;

2 Ниф. 25:20;

Алма 12:22–25.

су Гэтэлгэлийн

төлөвлөгөө.

в Иохан 1:14, 17;

Моце 1:6.

7а су Цагаатгах,

Цагаатгал.

өргөх ажгуу; мөн хуулийн ^ббүх шаардлагууд өөр хэний ч төлөө хангагдаж чадахгүй.

8 Иймийн тул, хамгийн эхэнд байж амилснаараа тэрээр, үхэгсдийн “амилуулалтыг гүйцэлдүүлж болохын тулд, өөрийн амийг маханбодийн дагуу өгч, Сүнсний хүчээр үүнийгээ дахин авах Ариун Мессиагийн сайн үйл мөн нигүүдсэл, мөн ач ивээлээр биш ^бболбоос нэг ч бие Бурханы дэргэд оршиж чадахгүйг тэд мэдэж болохын тулд эдгээр зүйлийг газар дэлхийн оршин суугчдад мэдүүлэх нь хичнээн их чухал билээ.

9 Иймийн тул, тэрээр бүх хүмүүний үрсийг “өмгөөлөхийн учир, тэрээр Бурханы хувьд эхний үр жимс бөлгөө; мөн түүнд итгэх тэд аврагдах болно.

10 Мөн “бүгдэд зориулагдсан өмгөөллийн учир, бүх хүмүүн Бурханд ирнэ; иймийн тул, түүнд байх үнэн болон ^бариун байдлын дагуу түүгээр ^бшүүгдэхийн тулд тэд түүний дэргэд зогсох болно. Иймийн тул, ^бцагаатгалын зорилгыг гүйцэлдүүлэхээр, тогтоогдсон шийтгэлийг оногдуулах, тогтоогдсон аз жаргалын эсрэг байх тэрхүү тогтоогдсон шийтгэл, Ариун Нэгэний

өгсөн хуулийн тэр шаардлагууд—

11 Учир юун хэмээвээс бүх зүйлд “сөрөг тал байх нь зайлшгүй. Хэрэв тийм бус аваас, аглаг буйдад төрсөн ууган хүү минь, зөв шударга нь бас ёсон бус ч, ариун нандин хийгээд зовлон шаналал ч, сайн бас муу ч тохиохгүй болой. Иймийн тул, бүх зүйл нэгэнд нийлэн байх нь зайлшгүй; иймийн тул, хэрэв энэ нь нэгэн биед оршвоос энэ нь үхдэл лугаа адил байх ёстой, үхэл үгүй бас амьдрал ч үгүй, ялзрал үгүй бас муу-дашгүй байдал ч үгүй, зовлонгүй бас жаргал ч үгүй, мөн хатуу сэтгэл үгүй бас саруул ухаан ч гэж байх нь үгүйн учир буюу.

12 Иймийн тул, хоосон зүйлийн тулд зайлшгүй бүтээгдэх ёстой байсан; иймийн тул, үүний бүтээлтийн “зорилгод утгагүй байх байсан. Иймийн тул, энэ зүйл нь Бурханы мэргэн ухаан мөн түүний мөнхийн зорилгууд, мөн түүнчлэн Бурханы хүч, мөн нигүүдсэл, мөн ^бшударга ёсыг зайлшгүй устгах бөлгөө.

13 Мөн хэрэв та нар “хууль үгүй хэмээвээс, та нар түүнчлэн нүгэл гэж үгүй гэх болно. Хэрэв та нар нүгэл үгүй хэмээн хэлэх аваас, та нар

76 Ром 10:4.

8a 1 Кор. 15:20;

Алма 7:12; 12:24–25; 42:23.

су Амилуулалт.

б 2 Ниф. 25:20; 31:21;

Мозая 4:8; 5:8;

Алма 38:9.

9a Иса. 53:1–12;

Мозая 14:12; 15:8–9.

10a су Гэтэлгэгч.

б су Ариун байдал.

в су Эцсийн шүүлт.

г 2 Ниф. 9:7, 21–22, 26;

Алма 22:14; 33:22;

34:9.

11a С ба Г 29:39; 122:5–9.
су Дайсан.

12a С ба Г 88:25–26.

су Газар дэлхий—
Хүмүүнд зориулан
бүтээгдэв.

б су Шударга ёс.

13a 2 Ниф. 9:25.

түүнчлэн зөв шударга гэж үгүй гэх болно. Мөн хэрэв зөв шударга гэж үгүй аваас аз жаргал ч үгүй байх буюу. Мөн хэрэв зөв шударга бас аз жаргал ч үгүй бол шийтгэл бас зовлон ч үгүй бөлгөө. Мөн хэрэв эдгээр зүйлүүд үгүй бөгөөс Бурхан гэж үгүй. Мөн хэрэв ⁶Бурхан үгүй бөгөөс бид ч, мөн дэлхий ч үгүй байх байсан; учир нь юмсын бүтээл байхгүй, үйлдэх нь ч үйлдүүлэх нь ч бас үгүй бөлгөө; иймийн тул, бүх зүйл алга болох ёстой буюу.

14 Мөн эдүгээ, хөвгүүд минь, би та нарт хандан та нарын эрдэм мөн тусын тулд эдгээр зүйлийг ярьъя; өөрөөр хэлбэл Бурхан буй, мөн тэрээр бүх зүйлийг, тэнгэр мөн газрыг аль алиныг нь, мөн тэнд орших бүх зүйлийг, үйлдэх зүйлүүд болон “үйлдүүлэх зүйлийг аль алиныг нь ⁶бүтээсэн болой.

15 Мөн өөрийн мөнхийн “зорилгуудыг хүмүүний зорилтонд гүйцэлдүүлэхэд, тэрээр бидний анхны эх эцгийг мөн газар дээрх араатан амьтад бас агаар дахь жигүүртнийг, мөн эцэст нь хэлэхэд, бүтээгдсэн тэдгээр бүх зүйлийг бүтээсний дараа эсрэг талууд

нь зайлшгүй байх ёстой болжээ; бүр ⁶хориглогдсон ⁶жимс нь амьдралын ⁶модны эсрэг зүйл юм; нэг нь амттай мөн нөгөө нь гашуун бөлгөө.

16 Иймийн тул, Их Эзэн Бурхан хүнд өөрөө “үйлдэх боломжийг өгчээ. Иймийн тул, тэрээр нэгээр эсвэл нөгөөд ⁶татагдсан байхаас бусдаар хүн өөрөө үйлдэж чадахгүй байх сан билээ.

17 Мөн би, Лихай, уншсан зүйлүүдийнхээ дагуу, Бурханы нэгэн “тэнгэр элч, бичигдсэний дагуу тэнгэрээс ⁶унасан хэмээн бодох ёстой болов; иймийн тул, тэрээр Бурханы өмнө хорт мууг эрэлхийлсний учир ⁶чөтгөр болсон бөлгөө.

18 Мөн тэрээр тэнгэрээс унасан, мөн үүрд зовлонт болсны учир, тэрээр түүнчлэн бүх хүн төрөлхтний зовлонг “эрэлхийлсэн болой. Иймийн тул, тэрээр ⁶Евад хэлж, тийм ээ, чөтгөр болох, ⁶худал бүгдийн эцэг болох тэр, бүр хөгшин могой, иймийн тул тэрээр хэлж: хориглогдсон жимснээс хүрт, мөн та нар үхэхгүй, харин та нар Бурханы адил сайн болон мууг ⁶мэдэх болно хэмээв.

19 Мөн Адам Ева хоёр хориг-

13б Алма 42:13.

14а С ба Г 93:30.

б су Бүтээх, Бүтээл.

15а Иса. 45:18;

Алма 42:26;

Моисе 1:31, 39.

б Эхл. 2:16–17;

Моисе 3:17.

в Эхл. 3:6;

Алма 12:21–23.

г Эхл. 2:9;

1 Ниф. 15:22, 36;

Алма 32:40.

16а 2 Ниф. 10:23;

Алма 12:31.

су Сонгох эрх.

б С ба Г 29:39–40.

17а су Чөтгөр.

б Иса. 14:12; 2 Ниф. 9:8;

Моисе 4:3–4;

Абр. 3:27–28.

в су Чөтгөр.

18а 2 Ниф. 28:19–23;

3 Ниф. 18:18;

С ба Г 10:22–27.

б су Ева.

в 2 Ниф. 28:8;

Моисе 4:4.

г Эхл. 3:5; Алма 29:5;

Моро. 7:15–19.

логдсон жимснээс “хүртсэний дараа тэд ^бЕденийн цэцэрлэгээс газар боловсруулахаар зайлуулагдсан билээ.

20 Мөн тэд хүүхдүүд төрүүлэв; тийм ээ, бүр бүх дэлхийн “гэр бүлийг.

21 Мөн маханбодид байхдаа тэд “наманчилж болохын тулд, хүмүүний ^бүрсийн өдрүүд Бурханы тааллын дагуу уртасгагджээ; иймийн тул, Их Эзэн Бурхан хүмүүний үрсэд өгсөн тэрхүү зарлигуудын дагуу тэдний байдал ^бсорилтын байдал болж, мөн тэдний хугацаа уртассан бөлгөө. Өөрөөр хэлбэл бүх хүмүүн наманчлах ёстой гэсэн зарлиг тэрээр өгчээ; учир нь тэдгээр нь өөрсдийн эцэг эхийн алдсын учир ^ттөөрөлдсөнийг тэрээр бүх хүмүүнд үзүүлсэн юм.

22 Мөн эдүгээ, болгоогтун, хэрэв Адам зөрчил үйлдээгүй аваас тэрээр унахгүй, харин тэр Еденийн цэцэрлэгт үлдэх байсан билээ. Мөн бүтээгдсэн бүх зүйл тэд бүтээгдсэнийхээ дараа байсан тэр байдлаараа нэгэн адил үлдэх ёстой байсан бөлгөө; мөн тэд үүрд, мөн төгсгөлгүйгээр үлдэх ёстой байсан бөлгөө.

23 Мөн тэд “хүүхдүүдгүй байх байсан; иймийн тул тэд зовлонг мэдээгүйн учир, баяр баясал үгүй, гэм зэмгүй гэнэн байдалдаа үлдэх байсан; тэд нүглийг мэдэхгүй учир сайныг эс үйлдэх байсан билээ.

24 Гэвч болгоогтун, бүх зүйл, бүхнийг “мэдэгч түүний мэргэн ухаанд хийгдсэн билээ.

25 “Адам хүмүүн байж болохын тулд ^бунасан; мөн тэд “баясгалантай байж болохын тул хүмүүн ^ббайх бөлгөө.

26 Мөн тэрээр хүмүүний үрсийг уналтаас “гэтэлгэж болохын тулд, ^бМессиа цаг хугацааны бүрэн байдлын үед ирэх болно. Мөн тэд уналтаас гэтэлгэгдсэний учир тэд үүрдийн “чөлөөт, сайныг муугаас ялгаж мэдэх болсон; өөрсдийн төлөө үйлдэх мөн Бурханы өгсөн зарлигуудын дагуу, агуу хийгээд эцсийн өдөр ^ххуулийн шийтгэлээс бусдаар өөрсөд дээрээ үйлдүүлэх нь үгүй болой.

27 Иймийн тул, хүмүүн нь бие махбодийн дагуу “чөлөөт болой; мөн хүнд шаардлагатай болох бүх зүйл тэдэнд өгөгдсөн билээ. Мөн тэд бүх хүмүүний агуу их Зуучаар дамжуулан, эрх чөлөө болон

19a Алма 12:31.
су Адам Ева хоёрын Уналт.
б су Еден.
20a С ба Г 138:38–39.
21a Алма 34:32.
су Наманчлах, Наманчлал.
б Алма 12:24;
Мосе 4:23–25.
в су Мөнх бус, Мөнх

бус байдал.
г Иаков 7:12.
23a Мосе 5:11.
24a су Бурхан, Бурхан тэргүүтэн.
25a су Адам.
б Мосе 6:48.
су Адам Ева хоёрын Уналт.
в су Мөнх бус, Мөнх бус байдал.

г Мосе 5:10.
су Баяр баясгалан; Хүмүүн, Хүмүүс.
26a су Гэтэлгэлийн төлөвлөгөө.
б су Мессиа.
в Алма 42:27;
Хил. 14:30.
г су Хууль.
27a Гал. 5:1; Мосе 6:56.

᠖ мөнх амьдралыг ᠘ сонгох эсвэл чөтгөрийн хүч мөн боолчлолын дагуу, боолчлол болон үхлийг сонгох эрхтэй; учир нь тэрээр бүх хүмүүн өөрийн адил зовлонт байж болохыг эрэлхийлдэг бөлгөө.

28 Мөн эдүгээ, хөвгүүд минь, та нарыг агуу их “Зуучид найдан, мөн түүний агуу зарлигуудыг анхаараасай; мөн түүний үгсэд итгэлтэй байж, мөн түүний Ариун Сүнсний тааллын дагуу, мөнх амьдралыг сонгоосой хэмээнэ би;

29 Мөн тэрээр өөрийн хаант улсад та нарын дээр засаглаж болохын тулд, та нарыг доош “тамд авчран ᠖ боолчлох хүчийг чөтгөрийн сүнсэнд өгөх маханбодийн таалал мөн түүнд байх тэр хилэнцийн дагуу мөнхийн үхлийг бүү сонгоосой хэмээнэ.

30 Би эдгээр хэдэн үгсийг өөрийн хөвгүүд та бүгдэд хандан, өөрийн сорилтын эцсийн өдрүүдэд ярьсан билээ; мөн би бошиглогчийн үгсийн дагуу сайн хэсгийг сонгож авсан. Мөн та нарын бодгалиудын үүрдийн зол жаргалаас өөр эрмэлзэл надад байхгүй болой. Амен.

БҮЛЭГ 3

Египет дэх Иосеф нифайчуудыг үзэгдэлд харав—Тэрээр хожмын

үеийн үзмэрч Иосеф Смитийн талаар; Израилыг чөлөөлөх Мосегийн талаар; мөн Мормоны Ном ирэх тухай бошиглов. Ойролцоогоор мээ 588–570 он.

Мөн эдүгээ “отгон хүү Иосеф минь, би чамд хандан ярья. Чи миний зовлон зүдрэлийн аглаг буйдад төрсөн билээ; тийм ээ, миний хамгийн их харамсаж гашуудсан тэр өдрүүдэд эх чинь чамайг төрүүлсэн билээ.

2 Мөн хэрэв энэчлэн байж чи Израилын Ариун Нэгэний зарлигуудыг дагах аваас, чиний үүрдийн аюулгүй байдлын тулд чиний өв мөн ах нарынхтай чинь хамт үр удмын чинь өв болгохоор, хамгийн эрхэм сайхан нутаг болох, энэ “нутгийг түүнчлэн Их Эзэн чамд ариулан адислах болтугай.

3 Мөн эдүгээ, Иосеф, зүдгүүрүүдийнхээ аглаг буйдаас миний авчирсан отгон хүү минь, Их Эзэн чамайг үүрд адислаг, өөрөөр хэлбэл чиний үр удам бүрмөсөн “устгагдахгүй.

4 Учир нь болгоогтун, чи бол миний хэвлийн үр билээ; мөн бибээр Египетэд “боолчлолд хүргэгдэж асан ᠖ Иосефын удам бөлгөө. Мөн Иосефтой хийсэн Их Эзэний гэрээнүүд агуу юм.

5 Иймийн тул, Иосеф үнэхээр бидний үеийг “харсан

27᠖ су Мөнх амьдрал.

в су Сонгох, эрх.

28а су Зууч.

29а су Там.

᠖ Ром 6:16–18;

Алма 12:11.

3 1а 1 Ниф. 18:7.

2а 1 Ниф. 2:20.

су Амлалтын нутаг.

3а 2 Ниф. 9:53.

4а Эхл. 37:29–36.

᠖ Эхл. 39:1–2; 45:4;

49:22–26;

1 Ниф. 5:14–16.

5а исо Эхл. 50:24–38;

2 Ниф. 4:1–2.

буюу. Мөн түүний хэвлийн гарсан үрсийг Их Эзэн Бурхан Израилын угсааны төлөө ⁶зөв шударга ⁶мөчир болгон өсгөн шударга гэсэн Их Эзэний амлалтыг тэрээр олж авсан буюу; Мессиа бус, харин хугарсан байх хэдий ч Их Эзэний гэрээнүүдэд санагдах нэгэн мөчир хожмын өдрүүдэд ⁷Мессиа тэдэнд хүч чадлын суу билгээр, тэднийг ⁸харанхуйгаас гэрэлд авчрахаар тэдэнд мэдүүлэгдэх гэсэн тэр—тийм ээ, нуугдмал харанхуйгаас мөн боолчлолоос эрх чөлөөнд болой.

6 Учир нь Иосеф үнэхээр гэрчилж, өгүүлсэн нь: Миний “хэвлийн үрсээс сонгогдсон байх үзмэрчийг, Их Эзэн Бурхан минь тэр ⁶үзмэрчийг тодруулах болно.

7 Тийм ээ, Иосеф үнэхээр хэлэв: Их Эзэн надад ийн хэллээ: Би чиний хэвлийн үрсээс сонгогдсон “үзмэрчийг тодруулна; мөн тэрээр чиний хэвлийн үрсийн дунд өндөрөөр хүндлэгдэх болно. Мөн тэрээр өөрийн ах дүү нар болох чиний хэвлийн үрсийн хувьд, тэдэнд агуу үнэт болох, бүр миний эцэг өвгөдтэй чиний хийсэн тэр гэрээнүүдийн мэдлэгт тэднийг авчрах тэр ажлыг үйлдэхийг би түүнд зарлиг болгоно.

8 Мөн миний түүнд зарлиглах тэр ажлаас өөр, “нэгээхэн ч ажлыг хийх ёсгүйг би түүнд зарлиг болгон өгөх болно. Мөн би түүнийг өөрийн мэлмийд агуу болгох болно; учир нь тэрээр миний ажлыг хийх бөлгөө.

9 Мөн тэрээр, хүмүүсийг минь “чөлөөлнө, би та нарт тодруулна гэж миний хэлсэн тэр ⁶Мосегийн адил агуу байх болно, Ай Израилын угсаа.

10 Мөн чиний хүмүүсийг Египет нутгаас гаргахын тулд би Мосег тодруулах болно.

11 Гэвч би чиний хэвлийн үрсээс нэгэн үзмэрчийг тодруулна; мөн хэвлийн чинь үрд миний үгийг авчрах “хүчийг би түүнд өгнө—мөн зөвхөн миний үгсийг авчрах бус, Их Эзэн хэлрүүн, харин аль хэдийн тэдний дунд очсон байх тэдгээр, миний үгсэд итгүүлэх хүчийг буюу.

12 Иймийн тул, хэвлийн чинь үрс “бичиглэх болно; мөн Иудейн хэвлийн үрс бичиглэх болно; мөн чиний хэвлийн үрсээр бичигдэх тэр нь, мөн түүнчлэн ⁶Иудейн хэвлийн үрсээр “бичигдэх тэр нь буруу сургаалуудыг бүрмөсөн ⁷гүйсгэж мөн маргаан тэмцлийг намжаан, мөн хэвлийн чинь үрсийн дунд амар амгаланг тогтоон хамтран

5б Иаков 2:25.

в Эхл. 49:22–26;

1 Ниф. 15:12; 19:24.

су Их Эзэний талбай.

г 2 Ниф. 6:14;

С ба Г 3:16–20.

д Иса. 42:16.

6а С ба Г 132:30.

б 3 Ниф. 21:8–11;

Морм. 8:16.

су Үзмэрч.

7а су Бага Иосеф Смит

8а С ба Г 24:7, 9.

9а Ег. 3:7–10;

1 Ниф. 17:24.

б Мосе 1:41.

11а С ба Г 5:3–4.

12а су Мормоны Ном.

б 1 Ниф. 13:23–29.

в су Библи.

г Езек. 37:15–20;

1 Ниф. 13:38–41;

2 Ниф. 29:8; 33:10–11.

нэгдэх болно, мөн хожмын өдрүүдэд эцэг өвгөдийнх нь ^амэдлэгт тэднийг ^вавчирна, мөн түүнчлэн миний гэрээ-нүүдийн мэдлэгт буюу хэмээн Их Эзэн хэлэв.

13 Мөн чиний сэргээлтэнд, Ай Израилын угсаа, миний ажил миний бүх хүмүүсийн дунд эхлэн дүсэх тэр өдөр тэрээр сул доройгоос чадалтай болгогдох болно хэмээн Их Эзэн өгүүлэв.

14 Мөн тэрчлэн Иосеф бошиглож, хэлсэн нь: Болгоогтун, уг үзмэрчийг Их Эзэн адислах болно; мөн түүнийг устгахыг эрэлхийлэх тэд устгагдах болно; учир нь хэвлийн минь үрсийн талаар, Их Эзэнээс миний олсон, энэ амлалт гүйцэлдэх болно. Болгоогтун, энэ амлалтын биелэлтийн талаар би огт эргэлзэхгүй байна;

15 Мөн түүний нэр миний-хээр “нэрлэгдэх болно; мөн энэ нь түүний эцгийн ^бнэр байх болно. Мөн тэрээр надтай адил байх болно; уг зүйлийн учир түүний гараар Их Эзэн авчруулах, Их Эзэний хүчээр миний хүмүүсийг авралд авчрах болно.

16 Тийм ээ, тэрчлэн Иосеф бошиглов: бүр Мосегийн тухай амлалтанд би эргэлзээгүй шиг би үүнд эргэлзэхгүй байна; би чиний удмыг үүрд

“хадгалах болно хэмээн Их Эзэн надад хэлсний учир бөлгөө.

17 Мөн Их Эзэн хэлэв: Би Мосе гэгч нэгнийг тодруулах болно; мөн би түүнд саваанд хүчийг өгнө; мөн би түүнд бичиглэх чадварыг өгнө. Гэвч түүний хэлийг тэрээр ихийг ярихуйц тийм хэлэмгий болгохгүй, учир нь би түүнийг “ярихаар чадамгай болгохгүй. Харин гарынхаа хуруугаар би түүнд өөрийн хуулийг ^ббичих болно; мөн би түүний өмнөөс яригчийг тодруулах болно.

18 Мөн Их Эзэн надад түүнчлэн хэлэв: Би хэвлийн чинь үрсийн төлөө тодруулах болно; мөн би түүний өмнөөс яригч нэгнийг тодруулна. Мөн би, болгоогтун, би түүнд хэвлийн чинь удамд, чиний хэвлийн удмын бичиглэлийг бичих эрхийг өгөх болно; мөн чиний хэвлийн удмын яригч нэгэн үүнийг тунхаглах болно.

19 Мөн түүний бичих үгс нь хэвлийн чинь “удамд очих ёстой миний мэргэн ухаанд нийцэх эдгээр үгс болой. Мөн энэ нь хэвлийн чинь удам ^бгазар шорооноос тэдэнд хашгирсан мэт байх болно; учир нь би тэдний итгэлийг мэднэ.

20 Мөн тэд газар шорооноос “хашгирах болно; тийм ээ,

12d 1 Ниф. 15:14;
2 Ниф. 30:5;
Морм. 7:1, 5, 9–10.
e Моро. 1:4.
15a С ба Г 18:8.
б ИС—Т 1:3.

16a Эхл. 45:1–8.
17a Ег. 4:16.
б Дэд хууль 10:2, 4;
Мосе 2:1.
19a С ба Г 28:8.
б Иса. 29:4;

2 Ниф. 27:13; 33:13;
Морм. 9:30;
Моро. 10:27.
20a 2 Ниф. 26:16;
Морм. 8:23.

бүр өөрсдийн ах дүүст наманчлалыг болой, бүр олон үе тэднээс хойш өнгөрсөн хойно ч гэсэн. Мөнхүү улиран тохиох дор тэдний хашгирах дуу хадах болно, бүр тэдний үгсийн энгийн хялбарын дагуу буюу.

21 Тэдний итгэлийн учир тэдний “үгс миний амнаас гараад тэдний ах дүү нар болох хэвлийн чинь үрсэд очих болно; мөн би чиний эцэг өвгөдтэй хийсэн гэрээгээ санан би тэдний үгсийн сул доройг итгэлд нь хүчтэй болгоно.

22 Мөн эдүгээ, болгоогтун, хүү Иосеф минь, ийм маягаар миний өвөг “бошиглосон болой.

23 Иймийн тул, энэ гэрээний учир чи адислагдсан болой; учир нь чиний үр удам уг номын үгсийг сонсохын тулд тэд устгагдахгүй байх бөлгөө.

24 Мөн Израилын угсааныханд мөн чиний ах нарын үр удамд машид их сэргээлтийг улируулан авчрах, мөн Бурханы мэлмийд агуу их болох тэр зүйлийг хийх, мөн хүчит гайхамшгуудыг үйлдэх, нэтэд их итгэлийг агуулж, Бурханы мутарт зэмсэг байснаар, үгээр болон үйлээр аль алинаар нь ихэд сайныг хийх тэрхүү хүчит нэгэн тэдний дунд тодрох болно.

25 Мөн эдүгээ, адислагдсан болой чи, Иосеф. Болгоогтун чи бол бага; иймийн тул ах Нифайнхаа үгэнд орж бай, ингээд энэ нь бүр миний

ярьсан тэдгээр үгсийн дагуу гүйцэтгэгдэх болно. Наснаас хальж буй эцгийнхээ үгсийг сана. Амен.

БҮЛЭГ 4

Лихай өөрийн удамд сургамжилж мөн адислав—Тэрээр нас эцэслэж бас оршуулагдав—Нифай Бурханы сайн сайхныг алдаршуулав—Нифай өөрийн найдварыг Их Эзэнд үүрд хандуулав. Ойролцоогоор мээ 588–570 он.

Мөн эдүгээ, би, Нифай, Египетэд аваачигдсан “Иосефын талаар, эцгийнхээ ярьсан бошиглолуудын талаар өгүүлбэ.

2 Учир нь болгоогтун, тэрээр үнэхээр өөрийн бүх үр удмын талаар бошиглосон болой. Мөн түүний бичсэн “бошиглолуудаас, илүү чухал олон нь үгүй бөлгөө. Мөн тэрээр бидний тухай, мөн бидний ирээдүйн үеүдийн талаар бошиглов; мөн тэдгээр нь гуулин ялтсууд дээр бичигдсэн болой.

3 Иймийн тул, миний эцэг Иосефын бошиглолуудын талаар ярьснаа төгсгөл болгосны дараа, тэрээр Лемений хүүхдүүдийг, түүний хөвгүүд, мөн түүний охидыг дуудаж, мөн тэдэнд хандан: Болгоогтун, миний “ууган хүүгийн хөвгүүд болон охид болох хөвгүүд минь, мөн охид минь, та нарыг миний үгсийг чих тавин сонсоосой хэмээнэ би.

4 Учир нь Их Эзэн Бурхан ийн хэлэв: Та нар “миний зарлигуудыг дагахын хэрээр та нар уг нутагт дэгжинэ; харин та нар миний зарлигуудыг дагахгүй байхын хэрээр та нар миний дэргэдээс тусгаарлагдах болно.

5 Гэвч болгоогтун, хөвгүүд минь мөн охид минь, би та нарын дээр “адислал үлдээлгүйгээр булшиндаа одож чадахгүй; учир нь болгоогтун, хэрэв та нар өөрсдийн явбал зохих тэр “зам дээр өсгөгдсөн бол та нар үүнээс хагацахгүйг би мэдэж байна.

6 Иймийн тул, хэрэв та нар зүхэгдэх аваас, болгоогтун, тэр зүхэл та нараас зайлуулагдаж мөн та нарын эцэг эхийн “толгой дээр хариулагдахын тулд би адислалаа та нар дээр үлдээж байна.

7 Иймийн тул, миний адислалын учир Их Эзэн Бурхан та нарыг эрсдэхийг “зөвшөөрөхгүй; иймийн тул, тэрээр та нарт мөн та нарын үр удамд үүрд “нигүүлсэнгүй хандах болно.

8 Мөнхүү улиран тохиох дор миний эцэг Лемений хөвгүүд, охидод ярьснаа төгсгөл болгосны дараа, тэрээр Лемүелийн хөвгүүд, охидыг өөрийнхөө өмнө ирүүлэв.

9 Мөн тэрээр тэдэнд хандан, өгүүлсэн нь: Болгоогтун, миний хоёр дахь хүүгийн хөвгүүд, охид болох хөвгүүд минь,

мөн охид минь; болгоогтун, Лемений хөвгүүд, охидод үлдээсний адил адислалыг би та нарт үлдээе; иймийн тул, та нар тэр чигээрээ устгагдахгүй; харин эцэст нь таны үр удам адислагдах болно.

10 Мөнхүү улиран тохиох дор эцэг минь тэдэнд ярьснаа төгсгөл болгоход, болгоогтун, тэрээр “Ишмэилийн хөвгүүдэд хандан ярив, тийм ээ, мөн түүгээр үл барам түүний гэрийнхэнд бүгдэд нь бөлгөө.

11 Мөн тэрээр тэдэнд хандан ярьснаа төгсгөл болгосны дараа, тэрээр Самд хандан ярьж, өгүүлсэн нь: Чи болон чиний үр удам адислагдсан болой; чи дүү Нифайнхаа адил уг нутгийг өвлөхийн учир буюу. Мөн чиний үр удам түүний үр удамтай хамт тоологдох болно; мөн чи дүүгийнхээ нэгэн адил бай, мөн чиний үр удам түүний үр удмын адил байж; мөн чи өөрийн бүх өдрүүдэд адислагдах болно.

12 Мөнхүү улиран тохиох дор миний эцэг, Лихай, түүнд орших Их Эзэний Сүнс мөн өөрийн зүрх сэтгэлийн мэдрэмжийн дагуу, өөрийнхөө гэрийнхэнд бүгдэд нь ярьсны дараа, тэрээр өндөр настай болжээ. Мөнхүү улиран тохиох дор тэрээр нас нөгчиж, оршуулагдсан болой.

13 Мөнхүү улиран тохиох дор түүнийг нас нөгчсөнөөс

4а 2 Ниф. 1:9.
5а су Патриархын адислал.
б Сур. үгс 22:6.

6а С ба Г 68:25–29.
7а 2 Ниф. 30:3–6;
С ба Г 3:17–18.
б 1 Ниф. 13:31;

2 Ниф. 10:18–19;
Иаков 3:5–9;
Хил. 15:12–13.
10а 1 Ниф. 7:6.

хойш хэдхэн хоногийн дараа, Лемен Лемүел хоёр бас Ишмэилийн хөвгүүд Их Эзэний зэмлэлийн улмаас надад уурлаж байлаа.

14 Учир нь би, Нифай түүний үгийн дагуу, тэдэнд хандан ярихаар албадуулсан билээ; тухайлбал би тэдэнд олон зүйлийг ярьсан байв, мөн түүнчлэн миний эцэг нас нөгчихийн өмнө буюу; хэлсэн тэдгээрээс олон нь миний нөгөө ялтсууд дээр бичигдсэн билээ; миний “нөгөө ялтсууд дээр илүү түүхэн хэсэг нь бичигдсэний учир нь энэ болой.

15 Мөн “эдгээрийн дээр өөрийн дотоод сэтгэлийн зүйлийг мөн гуулин ялтсууд дээр сийлэгдсэн тэдгээр судруудын олныг би бичих ажгуу. Учир нь дотоод сэтгэл минь судруудад баясна, мөн зүрх минь тэдгээрийг ^бтунгаан, мөн хүүхдүүдийнхээ “эрдэм хийгээд тусын тулд тэдгээрийг бичиглэх бөлгөө.

16 Болгоогтун, “сэтгэл минь Их Эзэний зүйлүүдэд баясч; мөн ^бзүрх минь өөрийн үзсэн мөн сонссон зүйлийг үргэлж тунгаадаг.

17 Гэсэн хэдий ч, түүний агуу хийгээд гайхамшигт ажлуудыг надад үзүүлэх Их Эзэний агуу “сайн сайхан

байлаа ч, зүрх минь хашгирч: Ай ^бзолгүй хүн юм би! Тийм ээ зүрх минь маханбодийнхоо учир харуусч; бодгаль минь миний алдсуудын учир гацуудах ажгуу.

18 Би хүрээлэгдсэн нэгэн, намайг туйлын амархнаар “хавчих тэр уруу таталтууд болон нүглүүдийн улмаас болой.

19 Мөн намайг баясахыг хүсэхээр миний нүглүүдийн учир зүрх минь ёолно; гэсэн хэдий ч, би хэнд итгэснээ мэдэж байна.

20 Миний Бурхан миний дэмжлэг байсан; тэрээр аглаг буйд дахь зовлонгуудын минь дундуур намайг удирдсан; мөн тэрээр гүн далай дээр намайг хамгаалсан билээ.

21 Тэрээр намайг “хайраараа дүүргэв, бүр бүх бие минь төөнөгдтөл буюу.

22 Тэрээр миний “дайснуудыг, миний өмнө салгалах хүртэл нь тэднийг гутаасан буюу.

23 Болгоогтун, тэрээр өдөр гуйлтыг минь сонсож, мөн тэрээр надад шөнийн цагт “үзэгдлүүдээр мэдлэг өгсөн болой.

24 Мөн түүний өмнөх хүчит “залбирлууддаа би өдрөөр зориг төрдөг байв; тийм ээ, дуу хоолойгоо би дээдэд ил-

14a 1 Ниф. 1:16–17; 9:4.

15a 1 Ниф. 6:4–6.

б су Тунгаан бодох;

Судрууд.

в 1 Ниф. 19:23.

16a су Талархалтай,

Талархах, Талархал

өргөх.

б су Зүрх, сэтгэл.

17a 2 Ниф. 9:10;

С ба Г 86:11.

б Ром 7:24.

18a Ром 7:21–23;

Евр. 12:1; Алма 7:15.

21a су Хайр.

22a 1 Ниф. 17:52.

23a су Үзэгдэл.

24a Иаков 5:16;

1 Ниф. 2:16.

гээсэн; мөн тэнгэр элчүүд доош ирж, надад тохинуулсан бөлгөө.

25 Мөн түүний Сүнсний далавчнууд дээр миний бие үлэмж өндөр уулсын дээр “аваачигдсан болой. Мөн нүд минь агуу их зүйлийг болгоосон, тийм ээ, бүр хүмүүнд ахадхуйц агуу ихийг буюу; тиймийн тул би тэдгээрийг бичихгүй байхаар зарлигдуулсан болой.

26 Ай тэгээд, хэрэв би тийм агуу их зүйлийг харж байсан юм бол, хэрэв Их Эзэн хүмүүний үрсэд хандуулсан хүлцэлдээ тийм их нигүүлслээр айлчилсан юм бол, “яагаад зүрх сэтгэл минь шархирч мөн бодгаль минь гунигийн хөндийд хоргодон, мөн маханбодь минь эцэн, бас хүч чадал минь зүдгүүрүүдийнхээ учир сулрах билээ?

27 Мөн өөрийн маханбодийн учир яагаад би нүгэлд “бууж өгөх билээ? Тийм ээ, миний ^бамгаланг устган мөн бодгалийг минь зовоох тэр хилэнцэт нэгнийг зүрх сэтгэлдээ байрлуулан, “уруу таталтанд би яагаад зам тавих билээ? Би яагаад дайсныхаа учир уурлах билээ?

28 Бодгаль минь, сэр! Дахин битгий нүгэлд гудай. Баяс, Ай зүрх сэтгэл минь, мөн бодгалийн минь “дайсанд дахин битгий зай тавь.

29 Миний дайснуудын улмаас дахин битгий бухимд. Зовлонгуудынхаа учир хүчийг минь битгий сулруул.

30 Баяс, Ай зүрх сэтгэл минь, мөн Их Эзэнд залбиран гуй, мөн хэл: Ай Их Эзэн, би таныг үүрд магтан дуулах болно; тийм ээ миний сүнс танд баясна, Бурхан минь, мөн авралын минь “хад билээ.

31 Ай Их Эзэн, та сүнсийг минь гэтэлгэнэ үү? Та дайснуудын минь гараас намайг чөлөөлнө үү? Та намайг “нүглийг хараад чичрэх нэгэн болгоно уу?

32 Миний өмнө тамын хаалга үргэлж хаалттай байг, “зүрх сэтгэл минь харуусч мөн бодгаль минь гэмшсэний учир буюу! Ай Их Эзэн, та зөв шударгынхаа хаалгуудыг миний өмнө бүү хаагаач, би дорд хөндийн замаар ^балхаж болохын тулд, би энгийн замд шулуун байж болохын тулд буюу!

33 Ай Их Эзэн, зөв шударгын орхимжоороо намайг ороогооч! Ай Их Эзэн, дайснуудынхаа өмнө зугтах замыг минь бэлтгээч! Та өмнөх замыг минь надад шулуутгаж өгөөч! Та замд минь тээглэх чулуу бүү байрлуулаач— харин өмнөх замыг минь бартаагүй байлгаач, мөн замд минь саад бүү босгооч, харин дайсны минь замд бөлгөө.

25a 1 Ниф. 11:1;

Моисе 1:1–2.

26a Дуул. 43:5.

27a Ром 6:13.

^б су Амар амгалан.

^в су Уруу татах, Уруу

таталт.

28a су Чөтгөр.

30a 1 Кор. 3:11.

су Хад.

31a Ром 12:9;

Алма 13:12.

32a су Харууссан зүрх.

^б су Алхах,

Бурхантай хатм

алхах.

34 Ай Их Эзэн, би танд “найдсан билээ, мөн би танд үүрд найдах болно. Би ^бнайдлагаа маханбодийн гарт тавих нь үгүй; учир нь ^анайдлагаа маханбодийн гарт тавьдаг тэрээр зүхэгддэгийг би мэднэ. Тийм ээ, найдлагаа хүмүүнд тавьдаг буюу маханбодийг гарга болгох тэрбээр зүхэгддэг болой.

35 Тийм ээ, гуйсан нэгэнд Бурхан “өгөөмрөөр соёрхох болно гэдгийг би мэднэ. Тийм ээ, Бурхан минь надад соёрхох болно, хэрэв би ^ббурууг ^агуйхгүй аваас; тиймийн тул би дуу хоолойгоо танд хандан өргөх болно; тийм ээ, Бурхан минь, миний зөв шударгын ‘хад, би танд хандан залбиран гуйх болно. Болгоогтун, дуу хоолой минь үүрд танд хандан дээш одох болно, миний хад, мөн миний үүрдийн Бурханд буюу. Амен.

БҮЛЭГ 5

Нифайчууд өөрсдийгөө леменчүүдээс тусгаарлаж, Мосегийн хуулийг даган, мөн ариун сүм барив—Итгэлгүйнхээ учир, леменчүүд Их Эзэний дэргэдээс тусгаарлагдаж, зүхэгдэж, мөн нифайчуудад цээрлэл болов. Ойролцоогоор мэв 588–559 он.

Болгоогтун, улиран тохиох

дор би, Нифай, Их Эзэн Бурхандаа ихэд залбиран гуйв, миний ах нарын “уур омгийн учир бөлгөө.

2 Гэвч болгоогтун, тэдний уур омог миний эсрэг нэмэгдсээр байв, үүнийхээ хэрээр тэд миний амийг авахаар эрэлхийлсэн болой.

3 Тийм ээ, тэд миний эсрэг бувтналдаж, өгүүлсэн нь: Дүү маань биднийг “захиран удирдахыг бодож байна; мөн бид түүнээс болж энэ их бэрхийг туулав; иймийн тул, түүний үгсийн учир дахин зовохгүй байж болохын тулд эдүгээ бүгдээрээ түүнийг алья. Учир нь болгоогтун, бид түүнийг захирагчаа болгохгүй; учир нь энэ хүмүүсийг захирах нь, ах нар нь болох бидэнд хамаарагдана.

4 Эдүгээ би эдгээр ялтсууд дээр миний эсрэг бувтналдсан тэдний бүх үгсийг бичихгүй. Гэвч тэд амийг минь авахаар эрэлхийлж байсныг хэлэх нь надад хангалттай.

5 Мөнхүү улиран тохиох дор би, “Нифай, мөн надтай явах тэд бүгд тэднээс зайлан мөн аглаг буйд тийш зугтахыг Их Эзэн надад ^бсэрэмжлүүлсэн билээ.

6 Иймийн тул, улиран тохиох дор би, Нифай, өөрийн гэр бүлийг, мөн түүнчлэн “Зорам болон түүний гэр

34а су Итгэл.
б Дуул. 44:6–8.
в Иер. 17:5;
Морм. 3:9; 4:8.
35а Иаков 1:5.
б Хил. 10:5.

в су Залбирал.
г Дэд хууль 32:4.
5 1а 2 Ниф. 4:13–14.
3а 1 Ниф. 16:37–38;
Мозая 10:14–15.
5а Мозая 10:13.

б су Сүнсний
удирдамж,
Сүнслэгээр
нөлөөлөгдөх.
6а 1 Ниф. 4:35; 16:7;
2 Ниф. 1:30–32.

бүлийг, мөн миний ах Сам болон түүний гэр бүлийг, мөн түүнчлэн миний дүү нар болох Иаков бас Иосеф, мөн түүнчлэн миний эгч нар, мөн надтай явах тэд бүгдийг авлаа. Мөн надтай хамт явах тэд бүгд Бурханы илчлэлт хийгээд ⁶сануулгад итгэсэн тэд билээ; иймийн тул, тэд миний үгсийг анхааран сонсов.

7 Мөн бид майхнуудаа мөн бидэнд боломжтой гэгдсэн бүх зүйлийг авч, мөн аглаг буйдад олон өдрийн турш зорчив. Мөн бид олон өдрийн турш аялсныхаа дараа бид майхнуудаа босгов.

8 Мөн миний хүмүүс уг газрыг бид “Нифай гэж нэрлэн дуудвал зохино хэмээв; иймийн тул, бид үүнийг Нифай гэж нэрлэв.

9 Мөн надтай байсан тэд бүгд өөрсдийгөө Нифайн “хүмүүс гэж дуудуулахаар өөрсөд дээрээ уг нэрийг авав.

10 Мөн бид Их Эзэний тогтоолуудыг мөн дүрмүүдийг, бас зарлигуудыг бүх зүйлүүдэд, Мосегийн “хуулийн дагуу даган мөрдөж байсан бөлгөө.

11 Мөн Их Эзэн бидэнтэй хамт байв, мөн бид үлэмж дэгжин байв; учир нь бид үр тарьж, мөн бид эргээд элбэг их ургац хурааж байв. Мөн

бид бог, мөн бод мал, бас төрөл бүрийн амьтдыг өсгөж эхлэв.

12 Мөн би, Нифай, түүнчлэн гуулин “ялтсууд дээр сийлэгдсэн тэдгээр цэдгүүдийг, мөн түүнчлэн бичиглэгдсэний дагуу Их Эзэний мутраар миний эцэгт бэлтгэгдсэн тэр ⁶бөмбөрцөг өөрөөр хэлбэл ⁶луужинг авчирсан буюу.

13 Мөнхүү улиран тохиох дор бид үлэмж дэвжиж, мөн уг нутагт өнөржиж эхлэв.

14 Мөн би, Нифай, эдүгээ “леменчүүд гэж нэрлэгдсэн тэдгээр хүмүүс биднийг довтолж мөн биднийг устгах бий хэмээснээс Лебений ⁶илдийг авч, үүний загвараар олон илд үйлдэв; учир нь миний зүг мөн хүүхдүүд минь мөн хүмүүс маань гэж нэрлэгдсэн тэдний зүг тэдний занал чиглэж буйг би мэдсэн бөлгөө.

15 Мөн барилгуудыг барихад, мөн бүх төрлийн модны ажилд, мөн “төмөр, мөн зэс, мөн гууль, мөн ган, мөн алт, бас мөнгөний, бас машинд элбэг дэлбэг байх үнэт хүдрүүдийн ажилд би өөрийн хүмүүсийг сургасан билээ.

16 Мөн би, Нифай, “ариун сүм босгов; мөн би үүнийг тийм олон ⁶үнэт зүйлээр барихаас бусдаар бол Соломоны

6б су Сэрэмжлэх,
Сэрэмжлүүлэг.
8а Омнаи 1:12, 27;
Мозая 9:1–4; 28:1.
9а Иаков 1:13–14.
10а 2 Ниф. 11:4.
су Мосегийн Хууль.
12а Мозая 1:3–4.

су Ялтсууд.
б Мозая 1:16.
в 1 Ниф. 16:10, 16, 26;
18:12, 21;
Алма 37:38–47;
С ба Г 17:1.
14а су Леменчүүд.
б 1 Ниф. 4:9;

Иаков 1:10;
Мор. үгс 1:13.
15а Ифер 10:23.
16а су Ариун Сүм, Их
Эзэний Өргөө.
б С ба Г 124:26–27.

“ариун сүмийн маягаар дуурайлган барив; учир нь тэдгээр нь уг нутгаас олдсонгүй, иймийн тул, энэ нь Соломоны ариун сүм шиг баригдаж чадсангүй. Гэвч барилгын төрх байдал нь Соломоны ариун сүмтэй адил байв; мөн үүний ур хийц үлэмж сайн байсан бөлгөө.

17 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, өөрийн хүмүүсийг “хөдөлмөрч байлгаж, мөн өөрсдийнх нь гараар ажиллуулж байлаа.

18 Мөнхүү улиран тохиох дор тэд намайг “хаанаа болгох гэв. Гэвч би, Нифай, тэд хаангүй байхыг хүсч байлаа; гэсэн хэдий ч, би тэдний төлөө хүч хүрэх бүхнээ хийсэн билээ.

19 Мөн болгоогтун, намайг тэдний захирагч мөн тэдний багш байна хэмээн Их Эзэн тэдний талаар ярьсан тэдгээр үгс ах нарын минь хувьд гүйцэлдсэн болой. Иймийн тул, би Их Эзэний зарлигуудын дагуу, тэд миний амийг авахаар эрэлхийлсэн цагийг хүртэл, би тэдний “захирагч мөн тэдний ⁶багш байсан билээ.

20 Иймийн тул, надад хандан ярьсан Их Эзэний үг гүйцэлдсэн бөлгөө, өгүүлсэн нь: Тэд чиний үгийг “дуулахгүй байхын хэрээр тэд Их Эзэний дэргэдээс тусгаарлагдах болно. Мөн болгоогтун, тэд

түүний дэргэдээс ⁶тусгаарлагдсан болой.

21 Мөн тэрээр “зүхлийг тэдний дээр ирүүлжээ, тийм ээ, бүр зовлонт зүхлийг, тэдний алдсын улмаас бөлгөө. Учир нь болгоогтун, тэд зүрх сэтгэлээ түүний эсрэг хатууруулсны учир, тэд цахиур чулуу лугаа адил болсон байв; иймийн тул, тэдэнд байсан цагаан мөн үлэмж хонгор мөн ⁶бахдам сайхан нь, тэд миний хүмүүсийн дурыг булаам биш байж болохын тулд Их Эзэн Бурхан тэдний дээр ⁶арьс нь харлах учрыг хийжээ.

22 Мөн Их Эзэн Бурхан тийн хэлэв: Тэд алдсуудаа наманчлахаас бусдаар би тэднийг чиний хүмүүсийн хувьд “зэвүүцэм муухай болгох болно.

23 Мөн тэдний үр удамтай “холилдогч түүний үр удам зүхэгдэх болно; өөрөөр хэлбэл тэд бүр нэгэн адил зүхлээр зүхэгдэх болно. Мөн Их Эзэн үүнийг хэлсэн, мөн энэ нь хийгдсэн болой.

24 Мөн тэдний дээр байсан тэдний тэрхүү зүхлийн учир, тэд аюул болон зальт аргаар дүүрэн, “залхуу хүмүүс болоод, аглаг буйдад идэшний амьтан эрж бэдрэх болов.

25 Мөн Их Эзэн Бурхан надад хандан хэлэв: Тэд чиний үр удамд намайг сануулахаар өдөөн хатгах цээрлэл болно;

16в Хаад. дээд 6;
Шаст. дэд 3.

17а Эхл. 3:19;
С ба Г 42:42.

18а Иаков 1:9, 11.

19а 1 Ниф. 2:22.
б су Заах, Багш.

20а 2 Ниф. 2:21.
б Алма 9:14.

21а су Хараах, Хараал.
б 4 Ниф. 1:10.

в 2 Ниф. 26:33;

3 Ниф. 2:14–16.

22а 1 Ниф. 12:23.

23а су Гэрлэлт,
Гэрлэх—Нэг адил
итгэлтэй хүмүүсийн
хоорондох гэрлэлт.

24а су Залхуурах,
Залхуу.

мөн тэд намайг санахгүй мөн миний үгсийг анхаарахгүй байхын хэрээр, тэднийг бүр устгалд нь хүртэл тэд цээрлүүлэх болно.

26 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, миний хүмүүсийн нутаг даяар тэд санваартнууд мөн багш нар байхын тулд Иаков Иосеф хоёрыг “томилон адислав.

27 Мөнхүү улиран тохиох дор бид аз жаргалтай хүмүүний ёсоор амьдарч байлаа.

28 Мөн бид Иерусалимыг орхисон цагаас хойш гучин жил улирч одов.

29 Мөн би, Нифай, өөрийн хийсэн ялтсууд дээр өдийг хүртэл өөрийн хүмүүсийн цэдгүүдийг үлдээсээр байлаа.

30 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Бурхан надад хандан хэлэв: “Өөр ялтсуудыг хий; мөн чи тэдний дээр миний мэлмийд сайн гэгдэх олон зүйлийг, өөрийн хүмүүсийн тусын тулд сийлбэрлэх бөлгөө.

31 Иймийн тул, би, Нифай, Их Эзэний зарлигуудад дуулгавартай байхын төлөө, явж мөн эдгээр зүйлүүдийг би дээр нь сийлсэн “эдгээр ялтсуудыг хийсэн болой.

32 Мөн би Бурханы хувьд таалалтайг сийлбэрлэсэн бөлгөө. Мөн хэрэв миний хүмүүс Бурханы зүйлүүдэд таалалтай байх аваас эдгээр ялтсууд дээрх миний сийлбэрүүд тэдэнд таалагдах болно.

33 Мөн хэрэв миний хүмүү-

сийн түүхийн илүү тодорхой хэсгүүдийг мэдэхийг миний хүмүүс хүсвэл тэд миний нөгөө ялтсуудыг судлах ёстой болно.

34 Мөн дөчин жил улиран өнгөрч мөн бид хэдийн ах нартайгаа дайтаж мөн тэмцэлдэж байсныг хэлэх нь миний хувьд хангалттай буюу.

БҮЛЭГ 6

Иаков иудейчүүдийн түүхийг хүүрнэв: Вавилонд боолчлогдож мөн эргэж ирэх ажгуу; Израилын Ариун Нэгэний тохинуулал мөн цовдлуулалт; Харийнханаас авсан тусламж; мөн Мессиад итгэсэн үед тохиох иудейчүүдийн хожмын өдрийн сэргээлт оршвой. Ойролцоогоор мээ 559–545 он.

Нифайн хүмүүст түүний хандан ярьсан Нифайн дүү болох, Иаковын үгс:

2 Болгоогтун, миний хайрт ах дүү нар минь, би, Иаков, Бурханаар дуудагдаж, мөн түүний ариун жаягийн дагуу томилогдсон, мөн “хаан эсвэл хамгаалагч мэт та нарын үздэг, мөн та нар аюулгүй байдлаа даатгадаг, өөрийн ах болох Нифайгаар томилогдон адислагдсаны учир, болгоогтун би та нарт хандан үлэмж олон зүйл ярьж байсныг та нар мэднэ.

3 Гэсэн хэдий ч, би та нарт хандан дахин ярья; учир нь би та нарын сүнснүүдийн зол

жаргалыг хүснэ. Тийм ээ, та нарын төлөө миний зовнил асар их байна; мөн үргэлж ийм байсныг та нар өөрсдөө мэднэ. Учир нь би та нарыг байдгаараа хичээнгүйлэн ухуулсан болой; мөн та нарт эцгийнхээ үгсийг заасан буюу би; мөн та нарт хандан энэ дэлхийн бүтээлтээс эхлэн бичигдсэн тэдгээр бүх зүйлийн талаар ярьсан буюу би.

4 Мөн эдүгээ, болгоогтун, би та нарт хандан, байгаа мөн ирэх тэдгээр зүйлүүдийн талаар ярих болно; иймийн тул, би та нарт “Исаиагийн үгсийг унших болно. Мөн тэдгээр нь та нарт намайг хандан ярихыг хүссэн ахын минь үгс болой. Мөн өөрсдийнхөө төлөө, та нар Бурханыхаа нэрийг мэдэж мөн алдаршуулж болохын учир би та нарт ярих ажгуу.

5 Мөн эдүгээ, миний унших үгс болох тэдгээр нь бүх Израилын угсааны талаар Исаиагийн ярьсан нь бөлгөө; иймийн тул, та нар Израилын угсааных учир, тэдгээр нь та нартай адилтгагдаж болно хэмээв. Мөн та нар Израилын угсааныхан учраас Исаиагаар яригдсан, та нартай адилтгагдаж болох олон зүйл буй бөлгөө.

6 Мөн эдүгээ, тэрхүү үгс нь эдгээр болой: Их Эзэн Бурхан

“тийн хэлэв: Болгоогтун, би мутраа Харийнханд өргөнө, мөн ^бдалбаагаа хүмүүсийн тулд тогтоох болно; мөн тэд чиний хөвгүүдийг гар дээрээ авчирч, мөн чиний охид тэдний мөрөн дээр зөөгдөх болно.

7 Мөн хаад чиний асрагч эцгүүд мөн тэдний хатад чиний асрагч эхүүд байх болно; тэд чиний өмнө нүүрээ газарт хандуулан бөхийж, мөн чиний хөлийн тоосыг долоох болно; мөн би бол Их Эзэн гэдгийг чи мэдэх болно; учир нь намайг “хүлээх тэд ичихгүй айх болно.

8 Мөн эдүгээ би, Иаков, эдгээр үгсийн талаар заримыг ярья. Учир нь болгоогтун, бидний орхиж явсан, “Иерусалимд байсан тэд алагдаж мөн ^ббоолчлолд хүргэгдсэнийг Их Эзэн надад үзүүлсэн билээ.

9 Гэсэн хэдий ч, Их Эзэн тэдний “буцаж ирэхийг надад үзүүлсэн. Мөн тэрээр түүнчлэн Их Эзэн Бурхан, Израилын Ариун Нэгэн тэнд өөрийгөө биеэр харуулахыг үзүүлсэн; мөн тэрээр өөрийгөө тэнд харуулсны дараа тэд түүнийг цээрлүүлэн мөн түүнийг ^бцовдлох бөлгөө, надад хандан үүнийг ярьсан тэнгэр элчийн үгсийн дагуу буюу.

4а 3 Ниф. 23:1.
6а Иса. 49:22–23.

б су Туг.

7а Моисе 1:6;

С ба Г 133:45.

8а Ест. 2:6; 1 Ниф. 7:13;
2 Ниф. 25:10;

Омнаи 1:15;
Хил. 8:20–21.

б Хаад. дэд 24:10–16;
25:1–12.

су Израил—
Израилын
Тараагдалт.

9а 1 Ниф. 10:3.

б 1 Ниф. 19:10, 13;

Мозая 3:9;

3 Ниф. 11:14–15.

су Цовдлуулалт.

10 Мөн тэд Израилын Ариун Нэгэний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулж мөн зөрүүдэлсний дараа, болгоогтун, Израилын Ариун Нэгэний “шүүлтүүд тэдний дээр ирэх болно. Мөн тэд цохигдож мөн зовоогдох тэр өдөр ирэх буюу.

11 Иймийн тул, тэд нааш цааш туугдсаны дараа, тэнгэр элчийн тийн хэлсэнчлэн, олон нь маханбодиороо зовоогдсон байна, мөн итгэлтнүүдийн залбирлуудын учир, эрсдэх нь зөвшөөрөгдөхгүй байх болно; тэд тараагдаж, мөн цохигдож, мөн үзэн ядагдах болно, гэсэн хэдий ч, тэднийг Гэтэлгэгчийнхээ “мэдлэгт^б ирэх цагт, тэд өвлөх нутгууддаа дахин нэгдэн “цуглуулагдахын тулд Их Эзэн тэдэнд нигүүлсэнгүй хандах болно.

12 Мөн бошиглогчийн бичиглэсэн тэдгээр “харийнхан адислагдах болно; учир нь болгоогтун, хэрэв тэд наманчилж мөн Сионы эсрэг тэмцэхгүй бол, мөн өөрсдийгөө тэр агуу хийгээд^б жигшүүрт сүмд нэгтгэхгүй бол, тэд аврагдах болно; учир нь Их Эзэн Бурхан хүүхдүүдтэйгээ хийсэн^г гэрээнүүдээ тэрээр гүйцэлдүүлэх болно; мөн

энэ шалтгааны учир мөнөөх бошиглогч эдгээр зүйлийг бичиглэсэн болой.

13 Иймийн тул, Сионы мөн Их Эзэний гэрээт хүмүүсийн эсрэг тэмцэх тэд тэдний хөлийн тоосыг долоох болно; мөн Их Эзэний хүмүүс “ичгүүрлэгдэхгүй бөлгөө. Учир нь Их Эзэний хүмүүс бол түүнийг^б хүлээх тэд болой; учир нь тэд Мессиагийн ирэлтийг хүлээсээр л байх буюу.

14 Мөн болгоогтун, сайхь бошиглогчийн үгсийн дагуу, Мессиа дахин “хоёр дахь удаагаа тэднийг буцааж авахаар өөрийгөө бэлтгэх болно; иймийн тул, тэд түүнд итгэх тэр өдрийг ирэхэд, тэрээр тэдэнд өөрийгөө хүчинд мөн агуу их алдар суунд, тэдний дайснуудын^б устгалд “нотлон үзүүлэх болно; мөн түүнд итгэдэг нэгээхнийг ч тэрээр устгах нь үгүй.

15 Мөн түүнд үл итгэгч тэд “галаар бас шуургаар аль алинаар нь, бас газар хөдлөлтөөр бас цус урсалтуудаар, бас^б өвчин тахлаар бас өлсгөлөнгөөр “устгагдах болно. Мөн Их Эзэн бол Бурхан, Израилын Ариун Нэгэн гэдгийг тэд мэдэх болно.

16 Өөрөөр хэлбэл хүчтэнээс

10a Мат. 27:24–25.

11a Хосеа 3:5.

б 1 Ниф. 22:11–12;
2 Ниф. 9:2.

в су Израил—
Израилын
цугларалт.

12a 1 Ниф. 14:1–2;
2 Ниф. 10:9–10.

б су Чөтгөр—

Чөтгөрийн сүм.

в су Абрахамын
Гэрээ.

13a 3 Ниф. 22:4.

б Иса. 40:31;
1 Ниф. 21:23;
С ба Г 133:45.

14a Иса. 11:11;

2 Ниф. 25:17; 29:1.

б 1 Ниф. 22:13–14.

в 2 Ниф. 3:5.

15a Иаков 6:3.

б С ба Г 97:22–26.

в 2 Ниф. 10:16; 28:15;
3 Ниф. 16:8.

в Эцсийн өдрүүд,
Хожмын өдрүүд.

“идэш нь булаагдаж, эсвээс
 6 хуулийн дагуу олзлогдсон
 нь чөлөөлөгдөх үү?

17 Харин Их Эзэн хэлэв: Бүр
 чадалтай нэгний “олзлогдог-
 сод булаагдах болно, мөн
 аймшигт нэгний идэш ч чөлөөлөгдөх болно; учир нь
 6 Хүчит Бурхан гэрээт хүмүү-
 сээ “чөлөөлөх болно. Учир нь
 Их Эзэн тийн хэлэв: чамтай
 тэмцсэн тэдэнтэй би тэмцэх
 болно —

18 Мөн чамайг дарангуйлах
 тэднийг би өөрсдийнх нь ма-
 хаар хооллох болно; мөн тэд
 өөрсдийнхөө цусанд, амтат
 дарсанд лугаа адил согтох
 болно; мөн би бол Их Эзэн
 чиний Аврагч мөн чиний
 “Гэтэлгэгч, Иаковын 6 Хүчит
 Нэгэн гэдгийг бүх маханбодь
 мэдэх болно.

БҮЛЭГ 7

*Исаиа Мессиагийнхаар яриу—
 Мессиа эрдэмтний хэлтэй байх
 болно— Тэрээр занчигчдад ну-
 руугаа хандуулах болно— Тэрээр
 мэдлэгдэхгүй байх болно—
 Исаиагийн 50 дугаар бүлэгтэй
 харьцуул. Ойролцоогоор мээ
 559–545 он.*

Тийм ээ, өөрөөр хэлбэл Их
 Эзэн тийн хэлэв Би чамайг
 холдуулж, эсвэл би чамайг

үүрд зайлуулсан гэж уу? Ту-
 хайлбал Их Эзэн тийн хэлэв:
 Чиний эхийн гэрлэлт цуц-
 лагдсан баримт хаана байна?
 Би чамайг хэнд зайлуулан өгч,
 эсвэл ямар зээлдүүлэгчиддээ
 би чамайг худалдсан билээ?
 Тийм ээ, хэнд би чамайг ху-
 далдсан билээ? Болгоогтун,
 алдсуудынхаа төлөөснөөс чи
 өөрийгөө “худалдсан, мөн
 зөрчлүүдийн чинь учир эх
 чинь холдуулагдсан бөлгөө.

2 Иймийн тул, намайг ирээ-
 хэд хүн үгүй байв; намайг
 “дуудахад, тийм ээ, хариулах
 хэн ч үгүй байв. Ай Израил-
 нын угсаа, аварч чадахааргүй
 болж гар минь өчүүхэн ч
 гэсэн богинодсон нь үгүй
 буюу, эсвээс надад чөлөөлөх
 хүч үгүй гэж үү? Болгоогтун,
 зэмлэлээрээ би 6 далайг ха-
 тааж, би үүний “ус, голыг
 аглаг газар болгон мөн ус нь
 хатсаны учир 7 загас нь өм-
 хийрч, мөн тэд цангасны
 учир үхэх болно.

3 Би тэнгэрт “харыг өмсгөж,
 мөн би тэдний хучлагыг
 6 зотонгоор хийх бөлгөө.

4 Их Эзэн Бурхан эрдэмт-
 ний “хэлийг надад өгсөн нь,
 би та нарт үгийг улиралд нь
 хэрхэн ярихыг мэдэхийн тулд
 билээ, Ай Израилын угсаа.
 Та нарыг эцэх үед тэрээр өг-
 лөөнөөс өглөөд сэрээх буюу.

16а Иса. 49:24–26.
 б ө.х. Шүлэг 17-д
 өгүүлэгдсэн Их
 Эзэний гэрээт
 хүмүүс.
 17а 1 Ниф. 21:25.
 б су Иехова.
 в Хаад. дэд 17:39.

18а су Гэтэлгэгч.
 б Эхл. 49:24;
 Иса. 60:16.
 7 1а су Урвалт.
 2а Сур. үгс 1:24–25;
 Иса. 65:12;
 Алма 5:37.
 б Ег. 14:21;

Дуул. 106:9;
 С ба Г 133:68–69.
 в Иош. 3:15–16.
 г Ег. 7:21.
 3а Ег. 10:21.
 б Илч. 6:12.
 4а Лук 2:46–47.

Эрдэмтэн мэт сонсохын тулд чихийг минь тэрээр сэрээх ажгуу.

5 Их Эзэн Бурхан “чихийг минь нээсэн билээ, мөн би эсэргүүцсэн нь, мөн нүүр буруулсан нь ч үгүй.

6 Би нуруугаа “занчигчдад, мөн хацраа үсийг нь зулгаах тэдэнд өгсөн билээ. Би нүүрээ ичгүүрээс мөн нулималтаас нуугаагүй.

7 Учир нь Их Эзэн Бурхан надад туслах болно, тиймийн тул би шившиглэгдэхгүй. Тиймийн тул би царайгаа цахиур чулуу лугаа адил болгосон буюу, мөн би ичгүүрлэгдэхгүй гэдгээ би мэддэг бөлгөө.

8 Мөн Их Эзэн ойрхон байна, мөн тэрээр намайг зөвтгөх болно. Хэн надтай тэрслэх билээ? Нэгдэн зогсоцгооё. Хэн миний өрсөлдөгч билээ? Тэр миний дэргэд ирэг, мөн би түүнийг үгийнхээ хүчээр цохих болно.

9 Учир нь Их Эзэн Бурхан надад туслах болно. Мөн намайг “үгүйсгэх тэд бүгд, болгоогтун, тэд бүгд хувцас лугаа адил үжирч хуучран, мөн удган эрвээхий тэдгээрийг идэх болно.

10 Та нарын дунд хэн чинь Их Эзэнээс эмээж, түүний үйлчлэгчийн “дуу хоолойг дагаж, харанхуйд мөн гэрэл үгүй алхдаг вэ?

11 Болгоогтун гал түлж өөрс-

дийгөө очоор хүрээлүүлсэн та нар бүгд, “галынхаа гэрэлд мөн өөрт асаасныхаа очинд алхагтун. Та нар үүнийг миний гараас авах бөлгөө—та нар харамсан хэвтэх болно.

БҮЛЭГ 8

Эцсийн өдрүүдэд, Их Эзэн Сионыг тайтгаруулж мөн Израилыг нэгтгэх болно—Гэтэлгэгдэгсэд Сионд агуу их баяслын дунд ирэх болно—Исаиагийн 51 мөн 52 дугаар бүлгийн 1-2-той харьцуул. Ойролцоогоор мэв 559–545 он.

Анхаарагтун намайг, зөв шударгын араас дагах та нар. Харагтун та нар өөрсдийн тэндээс бүтээгдсэн тэр “хадыг, мөн та нарын ухагдаж гарсан тэр ормыг болой.

2 Харагтун өөрсдийн “эцэг Абрахамыг, мөн та нарыг төрүүлсэн “Сараг; өөрөөр хэлбэл би зөвхөн Абрахамыг дуудсан, мөн түүнийг адисалсан бөлгөө.

3 Өөрөөр хэлбэл Их Эзэн “Сионыг тайтгаруулах болно, тэрээр түүний бүх эзгүй газруудыг тайтгаруулах болно; мөн тэрээр түүний “аглаг буйдыг Еденийн адил, мөн түүний цөл газрыг Их Эзэний цэцэрлэг лугаа адил болгох болно. Баяр мөн баясал, талархал мөн аялгуут дуу тэндээс олдох болно.

4 Намайг анхаарагтун, хү-

5а С ба Г 58:1.

6а Мат. 27:26;

2 Ниф. 9:5.

9а Ром 8:31.

10а С ба Г 1:38.

11а Шүүгч. 17:6.

8 1а су Хад.

2а Эхл. 17:1–8;

С ба Г 132:49.

б Эхл. 24:36.

3а су Сион.

б Иса. 35:1–2, 6–7.

мүүс минь; мөн чих тавин сонс, Ай миний үндэстэн; учир нь “хууль надаас үүсэх болно, мөн хүмүүст ^бгэрэл болохын тулд би өөрийн шүүлтийг тогтоох болно.

5 Миний зөв шударга байдал ойр; миний “аврал тархсан, мөн миний мутар хүмүүсийг шүүх болно. ^бАрлууд намайг найдан хүлээнэ, мөн тэд мутарт минь итгэх болно.

6 Харцаа тэнгэрт хандуулагтун, мөн доош газрыг харагтун; тэгээд “тэнгэр нь утаа мэт ^бзамхран, мөн газар хувцас лугаа адил ^бүжрэх болно; мөн түүнд орших тэд дээрхийн адил үхэх болно. Харин миний аврал үүрд байх болно, мөн миний зөв шударга байдал үгүйсгэгдэхгүй байх болно.

7 Намайг анхаарагтун, зөв шударгыг та нар мэднэ, би хуулиа зүрх сэтгэлд нь бичсэн хүмүүс та нар, хүмүүний зэмлэлээс “бүү эмээгтүн, бас тэдний доромжлолуудаас битгий ай.

8 Учир нь удган эрвээхий тэднийг хувцас лугаа адил идэж орхих болно, мөн тэднийг өт ноос лугаа адил идэх болно. Харин миний зөв шударга байдал үүрд, мөн

миний аврал үеэс үед байх болно.

9 Сэр, сэрэгтүн! “Хүчээ авагтун, Ай Их Эзэний мутар; эртний өдрүүдийн адил сэр. Рахабыг хэрчиж, мөн лууг шархдуулсан тэр нь та бус уу?

10 Ёроолгүй гүн усыг мөн далайг хатаасан; далайн гүнийг суллагдагсдад гатлах “зам болгосон тэр нь та бус уу?

11 Тиймийн тул, Их Эзэнээр “гэтэлгэгдэгсэд эргэж ирнэ, мөн Сионд ^бдуулсаар орох болно; мөн үүрдийн баясал мөн ариун байдал тэдний тэргүүн дээр байх болно; мөн тэд баяр мөн баяслыг олж авах болно; харуусал хийгээд “гашуудал зайлан одох болно.

12 “Би бол тэрбээр; тийм ээ, би бол та нарыг тайтгаруулагч тэрбээр. Болгоогтун, үхэх тэр хүнээс мөн ^бөвс лугаа адил болгогдох тэр хүний хүүгээс “эмээх чи хэн билээ?

13 Мөн устгахад бэлэн байсан мэт дарлагчийн уур омгийн учир, өдөр бүр үргэлж айж, мөн тэнгэрийг асарлан мөн газрын суурийг тавьсан чамайг бүтээгч Их Эзэнийг “мартах хэн билээ? Мөнхүү дарлагчийн уур омог хаана байна?

14 Боолчлолд цөлөгдсөн нь

4а ЭСВЭЛ Сургаал, номлол.
б су Гэрэл, Христийн гэрэл.
5а су Аврал.
б 2 Ниф. 10:20.
6а 2 Петр 3:10.
б Евр. Тараагдах.
Дуул. 102:25–27.

в Евр. Доройтол, бууралт.
7а Дуул. 56:4, 11;
С ба Г 122:9.
9а С ба Г 113:7–8.
10а Иса. 35:8.
11а су Гэтэлгэх,
Гэтэлгэгдэх,
Гэтэлгэл.

б Иса. 35:10.
в Илч. 21:4.
12а С ба Г 133:47; 136:22.
б Иса. 40:6–8;
1 Петр 1:24.
в Иер. 1:8.
13а Иер. 23:27.

тэрээр суллагдаж болохын тулд, мөн тэрээр нүхэнд үхэхгүй байхын тулд, мөн тэрээр талхнаасаа салах вий хэмээх учир яаран сандрах бөлгөө.

15 Харин би бол “давалгаа нь хүрхэрсэн Их Эзэн чиний Бурхан, Түмний Их Эзэн гэдэг нь миний нэр болой.

16 Мөн би үгсээ аманд чинь хийж, мөн мутрын сүүдрээрээ чамайг халхалсан, би тэнгэрийг шигтгэж мөн газрын суурийг тавихын тулд мөн Сионд: Болгоогтун, та нар бол миний “хүмүүс гэдгийг хэлэхийн тулд болой.

17 Сэр, сэр, бос, Ай Иерусалим, Их Эзэний мутарт байх түүний “хилэгнэлийн “аягнаас уусан тэр—чи салгалуулах аягыг шавхан шаарыг нь ч мушгин уусан буюу—

18 Мөн Иерусалимын төрүүлсэн бүх хөвгүүдийн дунд түүнийг удирдах нэгээхэн ч алга; мөн түүний өсгөсөн бүх хөвгүүдээс түүний гараас хөтлөх хэн ч байсангүй.

19 Чиний хоосрол мөн устгал, мөн өлсгөлөн болон илд—чиний төлөө харамсах энэ хоёр “хөвгүүн чамд ирнэ—мөн хэнээр би чамайг тайтгаруулах билээ?

20 Чиний хөвгүүд шантарсан, энэ хоёроос бусад нь; тэд гудамж бүрийн эхэнд хэвтэнэ; тэд урхинд орсон зэрлэг бух лугаа адил Бурханы тань

зэмлэл болон Их Эзэний хилэнгээр дүүрэн байна.

21 Тиймийн тул эдүгээ үүнийг сонс, зовсон, мөн “согтсон та нар, харин дарсанд бус:

22 Их Эзэн тань тийн хэлж байна, Их Эзэн мөн чиний Бурхан өөрийн хүмүүсийн төлөө “өмгөөлөх ажгуу; болгоогтун, би салгалуулах аягыг чиний гараас авсан, миний хилэнгийн аяганы шаарыг буюу; чи үүнээс хойш үүнийг дахин уухгүй байх болно.

23 Харин “би чамайг зовоогч тэдний гарт үүнийг тавих болно; чиний бодгальд: Доош бөхий, бид дээгүүр чинь явж болохын тулд хэмээн хэлсэн тэдэнд буюу—мөн чи өөрийн биеийг дээгүүр тань явсан тэдэнд газар мөн гудамж мэт дэвссэн буюу.

24 “Сэр, сэр, “хүчээ авагтун, Ай “Сион; гоёмсог өмсгөлөө өмс, Ай Иерусалим, ариун хот; учир нь үүнээс хойш хөвч хөндүүлээгүй болон цэвэр бус нь чамд “орохгүй.

25 Шороо тоосоо сэгсэр; “босоод суу, Ай Иерусалим; хүзүүн дэх “хүлээснээсээ өөрийгөө сулла, Ай Сионы боолчлогдогч охин.

БҮЛЭГ 9

Иудейчүүд бүгд амлалтын нут-

15a 1 Ниф. 4:2.

16a 2 Ниф. 3:9; 29:14.

17a Лук 21:24.

б Иса. 29:9; Иер. 25:15.

19a Илч. 11:3.

21a 2 Ниф. 27:4.

22a Иер. 50:34.

23a Зех. 12:9.

24a Иса. 52:1–2.

б С ба Г 113:7–8.

в су Сион.

г Иоел 3:17.

25a ө.х. Тоосноос босч

ирэх хийгээд

хүндэтгэлд суух,

эцэст нь

гэтэлгэгдэх.

б С ба Г 113:9–10.

гууддаа цуглуулагдах болно—
Цагаатгал хүмүүнийг Унал-
таас суллах ажгуу—Үхэгсдийн
биес бушинаас мөн тэдний сүнс-
нүүд тамаас мөн диваажингаас
ирэх болно—Тэд шүүгдэх болно
—Цагаатгал үхлээс, тамаас,
чөтгөрөөс мөн төгсгөлгүй зов-
лонгоос авардаг—Зөв шударгыг
үйлдэгсэд Бурханы хаант улсад
аврагдах болно—Нүглүүдийн
шийтгэлүүд нь тохоогдох бо-
лой—Израилын Ариун Нэгэн
бол их хаалганы сахиул мөн.
Ойролцоогоор мэв 559–545 он.

Мөн эдүгээ, хайрт ах дүү нар
минь, та нар бүх Израилын
угсаатай Их Эзэн гэрээлсэн
түүний “гэрээнүүдийн талаар
мэдэж болох буюу хэмээн би
эдгээр зүйлсийг уншлаа—

2 Тэрээр иудейчүүдэд, өө-
рийн ариун бошиглогчдын
амаар ярьсан зүйлийн та-
лаар—бүр эхлэлээс хойш,
үеэс үед, тэд Бурханы үнэн
сүмд мөн сүрэгт “сэргээгдэх
тэр цагийг хүртэл; тэд өөрс-
дийн өвлөж авсан ^бнутгууд
болох гэртээ “цуглуулагдах
болно, мөн бүх амлалтын
нутгууддаа төвхнүүлэгдэх тэр
цагт буюу.

3 Болгоогтун, хайрт ах дүү
нар минь, Их Эзэн Бурхан
хүүхдүүд дээр тань цутгах
адислалуудын учир тэргүү-

нээ ямагт дээр “өргөж мөн та
нар баясаж болно хэмээн би
та нарт эдгээр зүйлсийг ярьж
байна.

4 Та нарын олон тань ирэх
зүйлүүдийн талаар мэдэхийн
тулд, ихийг судалсныг би
мэднэ; иймийн тул махан-
бодь маань элэгдэж мөн үхэх
ёстойг та нар мэддэгийг би
мэднэ; гэсэн хэдий ч, өөрс-
дийнхөө “биед Бурханыг бид
харах болно.

5 Тийм ээ, бидний тэндээс
ирсэн Иерусалимд тэдэнд
тэрээр өөрийгөө биеэр үзүү-
лэхийг та нар мэднэ гэдгийг
би мэднэ; энэ нь тэдний дунд
байх нь зайлшгүйн учир
боллой; бүх хүмүүн түүний
харьяалалд байж болохын
тулд, агуу их “Бүтээгч өөрий-
гөө маханбодиор хүмүүний
харьяалалд байлгаж, ^ббүх хү-
мүүний төлөө нас юүлэхийг
хүлцэх нь шаардагдсан учир
бөлгөө.

6 Агуу их Бүтээгчийн ни-
гүүлсэнгүй “төлөвлөгөөг гүй-
цэлдүүлэхийн тулд үхэл бүх
хүмүүний дээр улиран ир-
сэнчлэн ^бамилуулалтын хүч
байх ёстой болж, мөн ами-
луулалт нь хүмүүнд “уналтаас
шалтгаалан ирэх ёстой нь
зайлшгүй; мөн уналт нь зөрч-
лөөс шалтгаалан ирсэн буюу;
мөн хүмүүн уналтанд орсон

9 1а су Абрахамын
Гэрээ.

2а 2 Ниф. 6:11.

су Сайн мэдээний
сэргээлт.

б 2 Ниф. 10:7–8.

су Амлалтын нутаг.

в су Израил—

Израилын
цугларалт.

3а iso, Дуул. 24:7–10.

4а Иов 19:26;

Алма 11:41–45; 42:23;

Хил. 14:15;

Морм. 9:13.

5а су Бүтээх, Бүтээл.

б Иохан 12:32;

2 Ниф. 26:24;

3 Ниф. 27:14–15.

6а су Гэтэлгэлийн
төлөвлөгөө.

б су Амилуулалт.

в су Адам Ева хоёрын
Уналт.

учир тэд Их Эзэний дэргэдээс 'зайлуулагдсан билээ.

7 Иймийн тул, "хязгааргүй ^бцагаатгал байх нь зайлшгүй — цагаатгал хязгааргүй байхаас бусдаар бол энэ биеийн ялзрал муудашгүй болж чадахгүй. Иймийн тул, хүмүүний дээр ирсэн ^вэхний шүүлт төгсгөлгүйгээр 'үлдэх ёстой байсан бөлгөө. Мөн хэрэв тийм аваас, энэ маханбодь дахин хэзээ ч босохгүйгээр ялзран хэвтэж мөн үүний эх болох газарт үйрэх ёстой байсан буюу.

8 Ай Бурханы "мэргэн ухаан, түүний ^бнигүүлсэл мөн ^вач гавьяа! Учир нь болгоогтун, хэрэв 'маханбодь дахин хэзээ ч босохгүй аваас Мөнхийн Бурханы дэргэдээс дахин хэзээ ч босохгүйгээр ^дунаж тэгээд ^вчөтгөр болсон тэрхүү тэнгэр элчийн харьяалалд бидний сүнс орох ёстой болой.

9 Мөн бидний сүнснүүд түүнтэй адил болж, мөн бид чөтгөрүүд, чөтгөрийн ^вэлчүүд болж, Бурханыхаа дэргэдээс ^бтаслагдаж, мөн ^вхудал бүхний эцэгтэй хамт, өөртэй

нь адилаар зовлонд үлдэх байсан; тийм ээ, бидний анхны эцэг эхийг 'мэхэлсэн тэр, өөрийгөө гэрлийн ^дтэнгэр элч мэт болгон ^вхувиргаж мөн аллагын ^внууц хуйвалдаанд болон бүх төрлийн харанхуй дахь нууц хэргүүдэд хүмүүний үрсийг өдөөн хатгадаг тэр болой.

10 Энэхүү аймшигт мангасын атганаас зугтах бидний замыг бэлтгэх, Ай Бурханы маань сайн сайхан хичнээн агуу билээ; тийм ээ, тэр мангас, "үхэл болон ^бтам, биеийн үхэл мөн түүнчлэн сүнсний үхэл гэж миний нэрлэх тэр буюу.

11 Мөн бидний Бурхан Израилын Ариун Нэгэний ^вчөлөөлөх замын учир, энэ ^бүхэл, миний ярьсан, зуурдынх болох тэр нь үүнд буй үхэгсдийгээ чөлөөлөх болно; мөнхүү үхэл нь булш болой.

12 Мөн миний ярьсан сүнсний үхэл болох энэхүү ^вүхэл үхэгсдээ чөлөөлөх болно; мөнхүү сүнсний үхэл нь ^бтам болой; иймийн тул, үхэл болон там нь үхэгсдээ чөлөөлнө, мөн там нь олзлогдсон

6г 2 Ниф. 2:5.

7а Алма 34:10.

б су Цагаатгах,
Цагаатгал.

в Мозая 16:4–5;
Алма 42:6, 9, 14.

г Мозая 15:19.

8а Иов 12:13;

Абр. 3:21.

су Мэргэн ухаан.

б су Нигүүлсэнгүй,
Нигүүлсэл.

в су Ач ивээл.

г С ба Г 93:33–34.

д Иса. 14:12;

2 Ниф. 2:17–18;

Моисе 4:3–4;

Абр. 3:27–28.

е су Чөтгөр.

9а Иаков 3:11;

Алма 5:25, 39.

б Илч. 12:7–9.

в су Худал хэлэх.

г Эхл. 3:1–13;

Мозая 16:3;

Моисе 4:5–19.

д С ба Г 129:8.

е 2 Кор. 11:14;

Алма 30:53.

ё су Нууц

хуйвалдаанууд.

10а Мозая 16:7–8;

Алма 42:6–15.

б су Там.

11а су Чөлөөлөгч.

б су Биеийн үхэл.

12а су Сүнсний үхэл.

б С ба Г 76:81–85.

сүнснүүдээ чөлөөлөх ёстой, мөн булш нь олзлогдсон биесээ чөлөөлөх ёстой, мөн хүмүүний бие хийгээд ^ссүнснүүд нэг нэгэндээ дахин 'нэгдэх болно; мөн энэ нь Израилын Ариун Нэгэний амилуулалтын хүчээр байх буюу.

13 Ай Бурханы маань "төлөвлөгөө хичнээн агуу билээ! Учир нь нөгөө талаас нь харвал Бурханы ^бдиваажин зөв шударгыг үйлдэгчдийн сүнснүүдийг чөлөөлнө, мөн булш зөв шударгыг үйлдэгчдийн биеийг чөлөөлөх ёстой; мөн сүнс болон бие нь өөртөө дахин ^ннэгдэнэ, мөн бүх хүмүүн муудашгүй, мөн ^үүхэшгүй болж, мөн тэд амьд бодгаль байж, бидэнд махан бодид байгаагийн адил ^ттөгс ^ммэдлэгтэй байна, бидний мэдлэг төгс байхаас бусдаар буюу.

14 Иймийн тул, бид өөрсдийн бүх ^ггэм, өөрсдийн бохирын, мөн өөрсдийн ^ннүцгэн байдлын төгс ^ммэдлэгтэй байх болно; мөн зөв шударгыг үйлдэгсэд өөрсдийн жаргал, мөн өөрсдийн 'зөв шударга үйлүүдийн төгс мэдлэгтэй байх болно, ^ццэврээр ^ххувцасласан байсны, тийм ээ, бүр

зөв шударгын ^оорхимжтой байсны учир болой.

15 Мөнхүү улиран тохиох дор бүх хүмүүн, тэд үхэшгүй болох учраас, энэ эхний үхлээсээ амьдралд шилжих болно, тэд Израилын Ариун Нэгэний "шүүлтийн суудлын өмнө очих ёстой; мөн тэгээд ^шшүүлт ирнэ, мөн тийнхүү Бурханы ариун шүүлтийн дагуу тэд шүүгдэх ёстой.

16 Мөн зөв шударга тэд зөв шударгаараа байх болно, харин "бузар булай тэд ^ббузар булайгаараа л байх болно; иймийн тул, бузар булай тэд ^ччөтгөр мөн түүний элчүүд байдаг; мөн тэд өөрсдөд нь энд зориулан бэлтгэгдсэн ^үүүрдийн түймэрт очих болно; мөн тэдний зовлон, дөл нь үүрд болон үргэлж мөн төгсгөлгүйгээр дүрэлзэх галт болон хүхэрт ^ннуур лугаа адил болой; мөн энэ нь гарцаагүй Их Эзэн амьдын адил, өөрөөр хэлбэл Их Эзэн Бурхан үүнийг ярьсан, мөн энэ нь "улирч одох нь үгүй түүний мөнхийн ^үүг болой.

17 Ай Бурханы маань сүр хүчин хийгээд "шударга ёс! Учир нь тэрээр өөрийн бүх

12в су Сүнс.

г су Амилуулалт.

13а су Гэтэлгэлийн төлөвлөгөө.

б С ба Г 138:14–19.
су Диваажин.

в Алма 11:43.

г су Мөнх бус, Мөнх бус байдал.

д су Төгс.

е С ба Г 130:18–19.

14а су Гэм.

б Морм. 9:5.

в Мозая 3:25; Алма 5:18.

г су Зөв шударга,
Зөв шударга
байдал.

д су Цэвэр ариун,
Цэвэр ариун байдал.

е Сур. үгс 31:25.

ё С ба Г 109:76.

15а су Эцсийн шүүлт.

б Дуул. 19:9;

2 Ниф. 30:9.

16а су Бузар, Бузар
явдал.

б 1 Ниф. 15:33–35;

Алма 7:21;

Морм. 9:14;

С ба Г 88:35.

в су Чөтгөр.

г Мозая 27:28.

д Илч. 21:8;

2 Ниф. 28:23;

С ба Г 63:17.

е С ба Г 56:11.

ё Хаад. дээд 8:56;

С ба Г 1:38; Мосе 1:4.

17а су Шударга ёс.

үгсийг гүйцэлдүүлнэ, мөн тэдгээр нь түүний амнаас гарсан юм, мөн түүний хууль биелэгдэх ёстой.

18 Гэвч, болгоогтун, зөв шударгыг үйлдэгсэд, Израилын Ариун Нэгэний “гэгээнтнүүд, Израилын Ариун Нэгэнд итгэсэн тэд, дэлхийн ⁶загалмайнудыг тэвчиж мөн ичгүүрийг умартсан тэд ⁶дэлхийн сууринаас тэдэнд бэлтгэгдсэн тэрхүү Бурханы хаант улсыг ⁶өвлөх ажгуу, мөн тэдний баяр ⁶үүрд бялхаж байх болно.

19 Ай Израилын Ариун Нэгэн, Бурханы маань нигүүлслийн сүр хүчин! Учир нь тэрээр өөрийн гэгээнтнүүдийг “аймшигт мангас болох чөтгөр мөн үхэл, мөн ⁶там, мөн төгсгөлгүй зовлон болох тэр галт болон хүхэрт нуураас ⁶чөлөөлөх бөлгөө.

20 Ай Бурханы маань “ариун чанар хичнээн агуу их билээ! Учир нь тэрээр бүх зүйлийг ⁶мэддэг, мөн түүний мэдлэгээс гадуур нэгээхэн ч зүйл эс орших буюу.

21 Мөн хэрэв тэд түүний дууг анхааран сонсоос бүх хүмүүнийг “аварч болохын тулд тэрээр дэлхийд ирнэ; учир нь болгоогтун, тэрээр

бүх хүмүүний ⁶шаналлыг тэвчинэ, тийм ээ, амьдрагч бүхний шаналлыг, “Адамын гэр бүлд багтах эр, эм, мөн хүүхэд аль алиныхыг нь болой.

22 Бүх хүмүүний дээр амилуулалт тохиож болохын тулд мөн агуу их хийгээд шүүлтийн өдөр бүгд түүний өмнө зогсож болохын тулд, тэрээр үүнийг тэвчих бөлгөө.

23 Мөн тэд Израилын Ариун Нэгэнд төгс итгэлтэйгээр “наманчилж, мөн түүний нэрээр ⁶баптисм хүртэх ёстойг тэрээр бүх хүмүүнд зарлигласан билээ, эс бөгөөс тэд Бурханы хаант улсад аврагдаж чадахгүй.

24 Мөн хэрэв тэд наманчилж мөн түүний “нэрэнд итгэж, мөн түүний нэрээр баптисм хүртэж, мөн эцсээ хүртэл ⁶тэвчихгүй аваас, тэд “яллагдах ёстой; учир нь Их Эзэн Бурхан, Израилын Ариун Нэгэн үүнийг ярьсан бөлгөө.

25 Иймийн тул, тэрээр “хууль өгсөн буюу; мөн хууль ⁶өгөгдөөгүй тэнд шийтгэл үгүй байна; мөн шийтгэл үгүй тэнд ял үгүй бөлгөө; мөн ял үгүй тэнд Израилын Ариун Нэгэний нигүүлслүүд тэдний дээр цагаатгалын

18a су Гэгээнтэн.

б Лук 14:27.

в су Өргөмжлөл.

г С ба Г 45:58; 84:38.

д Алма 13:3.

е су Мөнх амьдрал.

19a 1 Ниф. 15:35.

б су Там.

в С ба Г 108:8.

20a су Ариун байдал.

б Алма 26:35;

С ба Г 38:2.

21a су Аврал.

б С ба Г 18:11; 19:18.

в су Адам.

23a су Наманчлах,

Наманчлал.

б су Баптисм,

Баптисм хүртээх.

24a су Есүс Христ—

Өөрсөд дээрээ Есүс

Христийн нэрийг

авах.

б су Тэвчих.

в су Ял.

25a Иаков 4:17.

су Хууль.

б Ром 4:15;

2 Ниф. 2:13;

Алма 42:12–24.

су Хариуцах,

Хариуцлага,

Хариуцлагатай.

учир орших ажгуу; учир нь тэд түүний хүчээр чөлөөлөгдсөн бөлгөө.

26 Тухайлбал “хууль” өгөгдөөгүй тэдэнд, бүгдийнх нь дээр түүний “шударга ёсны шаардлагыг” цагаатгал хангах учир, тэд аймшигт мангас болно, үхэл мөн там, мөн чөтгөр, мөн төгсгөлгүй зовлон болох тэрхүү галт болон хүхэрт нуураас чөлөөлөгдөх болой; мөн тэдэнд “амьсгал өгсөн, Израилын Ариун Нэгэн болох тэрхүү Бурханд тэд сэргээгдэх болно.

27 Гэвч бидэнд байгаагийн адил “хууль, тийм ээ, Бурханы бүх зарлигууд өгөгдсөн, мөн тэдгээрийг зөрчсөн, мөн сорилтын өдрүүдээ дэмий үрсэн түүнд халаг, учир нь түүний байдал аймшигтай байх болно.

28 Ай тэр хилэнцэт нэгний зальт “төлөвлөгөө! Ай хүмүүний “бардам зан, мөн эмзэглэл, мөн мунхаглал! Тэд аливааг “сураад өөрсдийгөө “ухаантай хэмээн санадаг, мөн тэд Бурханы “зөвлөмжийг эс анхаардаг, учир нь тэд үл ойшоож, тэд өөрсдөө мэднэ гэж боддог, иймийн тул, тэд-

ний мэргэн ухаан нь тэнэглэл байж мөн энэ нь тэдэнд ашиггүй эс өгнө. Мөн тэд мөхөх болно.

29 Гэвч хэрэв тэд Бурханы “зөвлөмжийг” анхааран сонсох аваас суралцсан байх нь сайн хэрэг.

30 Харин энэ дэлхийн зүйлүүдээр баян болох тэрхүү “баянд халаг. Тухайлбал тэд баян учраас “ядууг гадуурхдаг, мөн тэд номхон дөлгөөн хүмүүсийг хавчиж, мөн тэдний зүрх сэтгэл хөрөнгөн дээрээ байдаг; иймийн тул, тэдний хөрөнгө нь тэдний бурхан. Мөн болгоогтун, тэдний хөрөнгө нь тэдэнтэй хамт түүнчлэн мөхөх болно.

31 Мөн “сонсохыг үл хүсэх дүлийд халаг; учир нь тэд мөхөх болно.

32 Харахыг үл хүсэх сохорт халаг; учир нь тэд түүнчлэн мөхөх болно.

33 Зүрх сэтгэл нь хөндөгдөөгүй тэдэнд халаг, учир нь тэдний алдсуудын мэдлэг тэднийг эцсийн өдөр цохих болно.

34 “Худалчид халаг, учир нь тэрээр доош “тамд хөөгдөх болно.

26a Мозая 15:24;
С ба Г 137:7.
б Мозая 3:11.
в су Шударга ёс.
г 2 Ниф. 2:10;
Алма 34:15–16.
су Цагаатгал,
Цагаатгал.
д Эхл. 2:7;
С ба Г 93:33;
Абр. 5:7.
27a Лук 12:47–48.
28a Алма 28:13.

б су Хоосон үг,
Хоосон үг ярих.
в Лук 16:15;
2 Ниф. 26:20; 28:4, 15.
г Сур. үгс 14:6;
Иер. 8:8–9; Ром 1:22.
су Бардамнал;
Мэргэн ухаан.
д Алма 37:12.
су Зөвлөгөө.
29a Иаков 4:10.
б 2 Ниф. 28:26.
30a Лук 12:34;

1 Тим. 6:10;
С ба Г 56:16.
б су Ядуу.
31a Езек. 33:30–33;
Мат. 11:15;
Мозая 26:28;
С ба Г 1:2, 11, 14;
Мосе 6:27.
34a Сур. үгс 19:9.
су Үнэнч, Үнэнч
шударга; Худал
хэлэх.
б су Там.

35 Санаатайгаар “егүүтгэх алуурчинд халаг, учир нь тэрээр ^бүхэх болно.

36 “Садар самууныг үйлдэгч тэдэнд халаг, учир нь тэд доош тамд хөөгдөх болно.

37 Тийм ээ, хиймэл шүтээнийг “бишрэгч тэдэнд халаг, учир нь бүх чөтгөрүүдийн чөтгөр тэдэнд баясах бөлгөө.

38 Мөн, эцэст нь, нүглүүддээ үхэх тэдэнд халаг; учир нь тэд Бурханд “эргэж очин, мөн түүний царайг болгоож, мөн нүглүүддээ үлдэх болно.

39 Ай, хайрт ах дүү нар минь, Ариун Бурханы эсрэг зөрчилдөх нь аймшигтайг, мөн түүнчлэн “башир нэгний уруу таталтуудад бууж өгөх нь аймшигтайг сана. ^бБиеэ бодох нь ^вүхэл, мөн сүнсээ бодох нь ^гмөнх ^дамьдрал гэдгийг сана.

40 Ай, хайрт ах дүү нар минь, миний үгсэд чих тавьцгаа. Израилын Ариун Нэгэний сүр жавхланг сана. Би та нарын эсрэг хатуу зүйлүүдийг ярьсан гэж битгий хэл; учир нь хэрэв та нар тэгвэл ^вүнэнийг эсэргүүцэн доромжилсон болно; өөрөөр хэлбэл та нарыг Бий Болгогчийн үгсийг

би ярьсан болой. Бүхий л цэвэр бусын эсрэг үнэн үгс ^бхатууг би мэднэ; харин зөв шударгыг үйлдэгчид тэдгээрээс эмээхгүй, учир нь тэд үнэнд дуртай мөн гуйвуулагдах нь үгүй.

41 Ай тэгээд, хайрт ах дүү нар минь, Ариун Нэгэн, Их Эзэнд “ирцгээ. Түүний замууд зөв шударгыг сана. Болгоогтун, хүмүүнд зориулагдсан ^бхаргуй ^внарийн, гэвч энэ нь түүний өмнө шулуунаар зурайна, мөн Израилын Ариун Нэгэн бол их ^вхаалганы сахиул; мөн тэрээр нэгээхэн зарцыг тэнд үл ажиллуулдаг; мөн уг хаалганаас өөр зам гэж үгүй; учир нь тэрээр мэхлэгдэх боломжгүй, түүний нэр Их Эзэн Бурхан билээ.

42 Мөн хэн тогшнов, түүнд тэрээр нээх болно; мөн ^вухаантай, мөн суралцсан, бас баян тэд, өөрсдийн боловсрол, мөн цэцэн ухаан, мөн баялгийнхаа учир ^бихэрхдэг — тийм ээ, тэд бол түүний гадуурхах тэд болой; тэд эдгээр зүйлүүдээ хаяж, мөн Бурханы өмнө өөрсдийн ^вмунхгийг мэдэж, мөн ^гдаруу байдлын гүнд доошлон

35a Ег. 20:13;

Мозая 13:21.

^б су Ухлийн шийтгэл.

36a 3 Ниф. 12:27–29.

су Ариун явдал.

37a су Хиймэл шүтээн.

38a Алма 40:11, 13.

39a 2 Ниф. 28:20–22;

32:8; Мозая 2:32;

4:14; Алма 30:53.

^б Ром 8:6.

су Тачаангуй,

Зуурдын.

^в су Сүнсний үхэл.

^г су Мөнх амьдрал.

^д Сур. үгс 11:19.

40a су Үнэн.

^б 1 Ниф. 16:2;

2 Ниф. 28:28; 33:5.

41a 1 Ниф. 6:4;

Иаков 1:7;

Омнаи 1:26;

Моро. 10:30–32.

^б 2 Ниф. 31:17–21;

Алма 37:46;

С ба Г 132:22, 25.

^в Лук 13:24;

2 Ниф. 33:9;

Хил. 3:29–30.

^г 2 Ниф. 31:9, 17–18;

3 Ниф. 14:13–14;

С ба Г 43:7; 137:2.

42a Мат. 11:25.

^б су Бардамнал.

^в 1 Кор. 3:18–21.

^г су Даруу, Даруу

байдал.

ирэхээс бусдаар бол, тэрээр тэдэнд нээхгүй байх болно.

43 Гэвч ухаантай мөн сэрэмжтэй хүний зүйлүүд тэднээс үүрд “далдлагдах болно — тийм ээ, гэгээнтнүүдэд бэлтгэгдсэн тэр аз жаргал болой.

44 Ай, хайрт ах дүү нар минь, миний үгсийг сана. Болгоогтун, би өмсгөлүүдээ тайлж, мөн би тэдгээрийг та нарын өмнө сэгсэрье; би авралын Бурхандаа тэрээр намайг “бүхнийг халиах мэлмийгээрээ тольдоосой хэмээн залбиръя; иймийн тул, бүх хүмүүн үйлүүдээрээ шүүгдэх тэр эцсийн өдөр би та нарын алдсуудыг өөрийн бодгалиас ^бсэгсэрснийг, мөн би түүний өмнө туяаран зогсохыг, мөн та нарын цуснаас ^аангигирсныг Израилын Бурхан гэрчилснийг та нар мэдэх болно.

45 Ай, хайрт ах дүү нар минь, нүглүүдээсээ салцгаа; та нарыг бөх гэгч нь хүлэх хүсэлтэй түүний “гинжийг сэгсрэн хая; авралын тань ^бхад болох Бурханд ирцгээ.

46 “Шударга ёс, зөв шударгыг үйлдэгчдэд хүртгээгдэнэ, та нар аймшигт айдсаасаа болж навтайхгүй байж болохын тулд, та нар аймшигт ^бгэмээ төгс санахгүй байж болохын тулд; мөн өөрийн эрхгүй дуу алдаж: Ариун, таны шүүлтүүд ариун юм, Ай Их Эзэн ^аБүхнийг Чадагч

Бурхан — гэвч би гэмээ мэднэ; би таны хуулийг зөрчсөн, мөн миний зөрчлүүд бол минийх; мөн чөтгөр намайг эзэмшиж, би түүний аймшигт зовлонгийн олз болжээ хэмээхгүй байж болохын тулд та нар өөрсдийн бодгалиудыг бүр шүүлтийн өдөр болох тэр дуурсгалт өдөрт бэлтгэцгээ.

47 Гэвч болгоогтун, ах дүү нар минь, эдгээр зүйлүүдийн аймшигт бодит байдалд та нарыг би сэрээх ёстой болж байгаа нь зүйд нийцнэ гэж үү? Хэрэв та нарын санаа бодол цэвэр байсан аваас би бодгалиудыг тань тарчилгана гэж үү? Хэрэв та нар нүглээс ангижирсан аваас үнэний тодорхой байдлын дагуу би та нарт тодорхойгоор ярих гэж үү?

48 Болгоогтун, хэрэв та нар ариун байсан аваас би та нарт ариун чанарын тухай ярихсан; гэвч та нар ариун бус учир, мөн та нар багшийгаа хэмээн надад хандах учир, би та нарт ^анүглийн уршгуудыг ^бсургах нь зайлшгүй байх ёстой зохист зүйл ажгуу.

49 Болгоогтун, бодгаль минь нүглийг жигшиж, харин зүрх сэтгэл минь зөв шударгад баясдаг; мөн би Бурханыхаа ариун нэрийг “магтан дуулах болно.

50 Ирцгээ, ах дүү нар минь,

43а 1 Кор. 2:9–16.

44а Иаков 2:10.

б Иаков 1:19.

в Иаков 2:2;

Мозая 2:28.

45а 2 Ниф. 28:22;

Алма 36:18.

б су Хад.

46а су Шударга ёс.

б Мозая 3:25.

в 1 Ниф. 1:14;

Моце 2:1.

г су Эцсийн шүүлт.

48а су Нүгэл.

б Алма 37:32.

49а 1 Ниф. 18:16.

цангасан бүхэн, та нар “усанд ирцгээ; мөн мөнгөгүй тэр нь, ирээд худалдаж ав мөн ид; тийм ээ, ирээд дарс болон сүүг ^бмөнгөгүйгээр мөн үнэгүйгээр худалдаж ав.

51 Иймийн тулд, үнэт биш зүйлд мөнгө, бас хэрэгцээг чинь хангаж чадахгүй зүйлд “хөдөлмөрөө бүү үр. Намайг хичээнгүйлэн сонс, мөн миний ярьсан эдгээр үгсийг сана; мөн Израилын Ариун Нэгэнд ир, мөн мөхөх нь үгүй тэр, бас ялзрах нь үгүй түүний дээр ^бнайрла, мөн бодгаль чинь шимт болгонд баясаг.

52 Болгоогтун, хайрт ах дүү нар минь, Бурханыхаа үгсийг сана; түүнд өдрөөр байнга залбирч бай, мөн шөнөөр түүний ариун нэрэнд “талархал мэдүүл. Зүрх сэтгэл чинь баярлаг.

53 Мөн болгоогтун Их Эзэний “гэрээнүүд хичнээн агуу их, мөн хүмүүний үрс дэх хүлцлүүд хичнээн агуу билээ; мөн түүний сүр жавхлан, мөн түүний ач ивээл болон ^бнигүүлслийн учир, бидний үр удам бие махбодийн дагуу бүрмөсөн устгагдахгүй, харин тэрээр тэднийг хадгалан хамгаалах болно хэмээн бидэнд амласан билээ; мөн ирээдүйн үеийнхэнд тэд

Израилын угсаанд нэгэн зөв шударга “мөчир байх болно.

54 Мөн эдүгээ, ах дүү нар минь, би та нарт илүүг ярихсан; гэвч маргааш би та нарт үгсийнхээ үлдсэнийг тунхаглах болно. Амен.

БҮЛЭГ 10

Иудейчүүд Бурханаа цовдлох болно—Тэд түүнд итгэж эхлэх хүртлээ тараагдах болно—Америк захирах хаангүй эрх чөлөөт нутаг байх болно—Өөрсдийгөө Бурханд нийцүүлэн, түүний ач ивээлээр авралыг ол. Ойролцоогоор мэв 559–545 он.

Мөн эдүгээ би, Иаков, та нарт дахин ярья, хайрт ах дүү нар минь, миний ярьсан зөв шударга “мөчрийн талаар буюу.

2 Учир нь болгоогтун, бидний хүртсэн “амлалтууд бидэнд маханбодид байхын дагуу амлалтууд юм; иймийн тул, бидний хүүхдүүдээс олон нь итгэлгүйн учир бие махбодиороо мөхнө, гэсэн хэдий ч, Бурхан олны дээр нигүүлсэнгүй байх болно гэдэг нь надад үзүүлэгдсэн билээ; мөн тэдний Гэтэлгэгчийн үнэн мэдлэгийг тэдэнд өгөх түүнд ирж болохын тулд бидний хүүхдүүд сэргээгдэх болно.

50a су Амьдралын ус.

б Алма 42:27.

51a Иса. 55:1–2.

б 2 Ниф. 31:20; 32:3;

3 Ниф. 12:6.

52a су Талархалтай,

Талархах, Талархал

өргөх.

53a су Гэрээ.

б су Нигүүлсэнгүй,

Нигүүлсэл.

в су Их Эзэний

талбай.

10 1a 1 Ниф. 15:12–16;

2 Ниф. 3:5;

Иаков 5:43–45.

2a 1 Ниф. 22:8;

3 Ниф. 5:21–26;

21:4–7.

3 Иймийн тул, би та нарт хэлсэнчлэн, Христ — учир нь өнгөрсөн шөнө “тэнгэр элч надад энэ нь түүний нэр байхыг ярилаа — Иудейчүүдийн дунд зайлшгүй ^бирэх ёстой, дэлхийн илүү ёсон бус хэсэг болох тэдний дунд болой; мөн тэд түүнийг ^цовдолно — өөрөөр хэлбэл тэрчлэн энэ нь бидний Бурханы зүгээс шаардагдах, мөн өөрсдийн ‘Бурханыг ^дцовдлох өөр ямар ч үндэстэн энэ дэлхий дээр үгүй.

4 Учир нь бусад үндэстнүүдийн дунд агуу ^агайхамшгууд бүтээгдсэн бол тэд наманчилж, мөн тэр бол өөрсдийнх нь Бурхан гэдгийг мэдэх бөлгөө.

5 Гэвч “санваараар мэргэших явдал мөн алдсуудын учир, Иерусалим дахь тэд түүний эсрэг зөрүүдлэх болно, тэгснээр тэр цовдлогдох болно.

6 Иймийн тул, тэдний алдсуудын учир, устгалууд, өлсгөлөнгүүд, тахлууд, мөн үсчих цус тэдний дээр ирэх болно; мөн устгагдахгүй тэд бүх үндэстний дунд ^атараагдах болно.

7 Гэвч болгоогтун, “Их Эзэн Бурхан ийн хэлэв: Би бол

Христ хэмээн надад итгэх тэр өдөр ^бирэхэд, тэр үед би тэдний эцэг өвгөдтэй тэд газар дэлхий дээр, өөрсдийн өв болох нутгуудад, бие махбодийн дагуу сэргээгдэх болно хэмээн гэрээлсэн болой.

8 Мөнхүү улиран тохиох дор тэд өөрсдийн удаан хугацааны тараагдалтаасаа, далайн “арлуудаас, мөн газар дэлхийн дөрвөн зүгээс ^бцуглуулагдах болно; мөн тэднийг өвийн нутгуудад нь ^ааваачихын хувьд харийнханы үндэстнүүд мэлмийд минь агуу байх болно хэмээн Бурхан хэлсэн болой.

9 “Тийм ээ, харийнханы хаад тэдэнд асрагч эцгүүд байх болно, мөн тэдний хатад асрагч эхчүүд нь болох болно; иймийн тул, харийнханд зориулсан Их Эзэний ^бамлалтууд агуу их, учир нь тэрээр үүнийг ярьсан болой, мөн хэн маргаж чадах билээ?

10 Гэвч болгоогтун, энэ нутаг, та нарын өвийн нутаг байх болно, мөн “харийнхан уг нутаг дээр адислагдах болно хэмээн Бурхан хэлжээ.

11 Мөн энэ нутаг нь харийнханд “эрх чөлөөний нутаг байх болно, мөн уг нутаг дээр

3а 2 Ниф. 25:19;

Иаков 7:5;

Моро. 7:22.

б су Есүс Христ — Есүс Христийн төрөлт болон нас баралтын тухай бошиглол.

в 1 Ниф. 11:33;

Мозая 3:9;

С ба Г 45:52–53.

г 1 Ниф. 19:10.

д Лук 23:20–24.

4а су Гайхамшиг.

5а Лук 22:2.

су Санваараар

мэргэших.

6а 1 Ниф. 19:13–14.

су Израил —

Израилын

тараагдалт.

7а су Их Эзэн.

б 2 Ниф. 25:16–17.

8а 1 Ниф. 22:4;

2 Ниф. 10:20–22;

С ба Г 133:8.

б су Израил —

Израилын

цугларалт.

в 1 Ниф. 22:8.

9а Иса. 49:22–23.

б 1 Ниф. 22:8–9;

С ба Г 3:19–20.

10а 2 Ниф. 6:12.

11а су Эрх чөлөө, Эрх чөлөөт.

харийнханд тодруулагдах
 6 хаад гэж үгүй байх болно.

12 Мөн би энэ нутгийг
 бусад бүх үндэстний эсрэг
 бэхлэх болно.

13 Мөн Сионы эсрэг “тулал-
 дах тэр нь 6 мөхөх болно хэмээн
 Бурхан хэлэх ажгуу.

14 Учир нь миний эсрэг
 хааныг тодруулах тэр мөхөх
 болно, учир нь бибээр, Их
 Эзэн, тэнгэрийн “хаан, тэд-
 ний хаан байх болно, мөн
 үгсийг минь анхааран сонсох
 тэдэнд би үүрд 6 гэрэл байх
 болно.

15 Иймийн тул тэднийг
 бие маханбодид байхад нь
 тэдэнд үйлдэх тэрхүү, хүмүү-
 ний үрсэд миний хийсэн
 миний “гэрээнүүд гүйцэл-
 дэж болох энэ шалтгааны
 учир, би 6 харанхуйн, мөн
 аллагуудын, мөн жигшүүрт
 хэргүүдийн “нуугдмал үйлүү-
 дийг устгах нь зайлшгүй
 байх ёстой.

16 Иймийн тул, “Сионы эс-
 рэг тулалдах тэрээр, Иудей
 ч мөн Харь ч бай, хоригдол ч
 мөн чөлөөт хүн ч бай, эр эм
 алин боловч мөхөх болно;
 өөрөөр хэлбэл 6 тэд бүх дэл-
 хийн садар эм бөлгөө; учир
 нь миний төлөө “бус 7 тэд бол

миний 8 эсрэг байдаг хэмээн
 бидний Бурхан хэлдэг.

17 Учир нь би тэдэнд бие
 маханбодид байхад нь үйлдэх
 болно хэмээн би хүмүүний
 үрсэд өгсөн тэр амлалтуудаа
 “гүйцэлдүүлэх болно —

18 Иймийн тул, хайрт ах дүү
 нар минь, бидний Бурхан
 ийн хэлсэн билээ: Би чиний
 үр удмыг харийнханы гараар
 зовоох болно; гэсэн хэдий ч,
 тэдэнд тэд эцгийн адил бай-
 хын тулд би “харийнханы
 зүрх сэтгэлийг зөөллөх болно;
 иймийн тул, уг харийнхан
 Израилын угсааныхны дунд
 6 тоологдож мөн 6 адислагдах
 болно.

19 Иймийн тул, би энэ нут-
 гийг чиний удамд, мөн чиний
 удмын дунд тоологдох тэ-
 дэнд, үүрд, тэдний өвлөсөн
 нутаг байлгахаар “ариулан
 адислах болно; Бурхан надад
 хэлснээр, тухайлбал энэ нь
 сонгомол нутаг билээ, бусад
 бүх нутгаас дээгүүр буюу, ий-
 мийн тул түүний дээр орших
 бүх хүмүүн намайг шүтэхийг
 би шаардах болно хэмээн
 Бурхан хэлэх ажгуу.

20 Мөн эдүгээ, хайрт ах дүү
 нар минь, бидний нигүүлсэн-
 гүй Бурхан бидэнд эдгээр

11б Мозая 29:31–32.

13а 1 Ниф. 22:14, 19.

б Иса. 60:12.

14а Алма 5:50;

С ба Г 38:21–22;

128:22–23;

Моисе 7:53.

б су Гэрэл, Христийн
 гэрэл.

15а су Гэрээ.

б су Сүнсний

харанхуй.

в Хил. 3:23.

су Нууц

хуйвалдаанууд.

16а су Сион.

б 1 Ниф. 13:4–5.

в 1 Ниф. 22:13–23;

2 Ниф. 28:15–32;

3 Ниф. 16:8–15;

Ифер 2:9.

г 1 Ниф. 14:10.

д Мат. 12:30.

17а С ба Г 1:38.

18а Лук 13:28–30;

С ба Г 45:7–30.

б Гал. 3:7, 29;

1 Ниф. 14:1–2;

3 Ниф. 16:13; 21:6,

22; 30:2;

Абр. 2:9–11.

в Ефес 3:6.

19а 2 Ниф. 3:2.

зүйлүүдийн талаар ийм агуу мэдлэг өгсний учир, түүнийг санацгаая, мөн нүглүүдээ холдуулж, мөн тэргүүнээ огтхон ч үл гудайлгацгаая, учир нь бид зайлуулагдаагүй билээ; бид өвлөсөн нутгаасаа “гаргагдсан хэдий ч; гэвч бид ^билүү сайхан нутаг тийш удирдагдсан, учир нь Их Эзэн далайг бидний “харгуй болгосон бөгөөд бид далайн “арал дээр байх бөлгөө.

21 Харин Их Эзэний амлалтууд далайн “арлууд дээрх тэдэнд агуу их билээ; иймийн тул үүнд арлууд хэмээн хэлсний учир, үүнээс гадна байх нь зайлшгүй, мөн түүнчлэн тэдгээр нь бидний ах дүү нараар эзэмшигдэх болно.

22 Учир нь болгоогтун, Их Эзэн Бурхан Израилын угсаанаас цагаас цагт, өөрийн дур мөн тааллын дагуу “гадагш удирдсан буюу. Мөн эдүгээ болгоогтун, Их Эзэн салгадах тэд бүгдийг санах болно, иймийн тул тэрээр түүнчлэн биднийг ч санах бөлгөө.

23 Тиймийн тул, зүрх сэтгэлээ урамтай болгоцгоо, мөн та нар өөрсдөдөө “үйлдэх ^бэрх чөлөөтэй гэдгээ сана — үүрдийн үхлийн зам, эс бөгөөс мөнх амьдралын замыг “сонгох тэр ажгуу.

24 Иймийн тул, хайрт ах дүү нар минь, Бурханы таалалд

өөрсдийгөө эвлэрүүл, харин чөтгөрийн болон биеийн таалалд бус; мөн та нар Бурханд эвлэрүүлэгдсэнийхээ дараа, та нар “аврагдана, энэ нь зөвхөн Бурханы “ач ивээлд мөн үүний дагуу байна гэдгийг санагтун.

25 Иймийн тул, та нар бурханлиг ач ивээлийн дагуу түүнийг магтан дуулж болохын тулд, та нар мөнхийн Бурханы хаант улсад хүлээн зөвшөөрөгдөж болохын тулд, Бурхан та нарыг үхлээс амилуулалтын хүчээр, мөн түүнчлэн “цагаатгалын хүчээр үүрдийн үхлээс босгох болтугай. Амен.

БҮЛЭГ 11

Иаков өөрийн Гэтэлгэгчийг харав—Мосегийн хууль Христийг бэлэддэж мөн түүний ирэлтийг нотолдог. Ойролцоогоор мээ 559–545 он.

Мөн эдүгээ, “Иаков тэр цагт илүү олон зүйлийг миний хүмүүст ярив; гэсэн хэдий ч зөвхөн эдгээр зүйлийг би бичүүлэв, өөрөөр хэлбэл миний ^ббичиглэсэн тэдгээр зүйлүүд нь миний хувьд хангалттай.

2 Мөн эдүгээ би, Нифай, “Исаиагийн үгсээс дахиад заримыг нь бичье, учир нь бодгаль минь түүний үгсэд

20a 1 Ниф. 2:1–4.
 б 1 Ниф. 2:20.
 су Амлалтын нутаг.
 в 1 Ниф. 18:5–23.
 г Иса. 11:10–12.
 21a 1 Ниф. 19:15–16; 22:4.

22a 1 Ниф. 22:4.
 23a су Сонгох эрх.
 б 2 Ниф. 2:16.
 в Дэд хууль 30:19.
 24a су Аврал.
 б су Ач ивээл.

25a су Цагаатгах,
 Цагаатгал.
 11 1a 2 Ниф. 6:1–10.
 б 2 Ниф. 31:1.
 2a 3 Ниф. 23:1.

баясах бөлгөө. Өөрөөр хэлбэл би түүний үгсийг өөрийн хүмүүстэй адилтгана, мөн би тэдгээрийг өөрийн бүх хүүхдүүдэд улируулан илгээх болно, учир нь тэрээр миний ⁶Гэтэлгэгчийг үнэхээр харсан, бүр би түүнийг харсны адил болой.

3 Мөн би түүнийг харсны адилаар миний дүү, Иаков, түүнчлэн түүнийг “харсан билээ; иймийн тул, би үгс маань үнэн гэдгийг нотлохын тулд тэдний үгсийг хүүхдүүдэд илгээх болно. Иймийн тул, ⁶гурвын үгсээр, Бурхан хэлж, би өөрийн үгийг тогтоох болно гэжээ. Гэсэн хэдий ч, Бурхан илүү олон гэрчийг илгээх болно, мөн өөрийн бүх үгсийг тэрбээр нотлох ажгуу.

4 Болгоогтун, Христийн “ирэлтийн үнэнийг өөрийн хүмүүст ⁶нотлохдоо бодгаль минь баяснам; учир нь энэ зорилгын тулд Мосегийн “хууль өгөгдсөн болой; мөн хүмүүнд, энэ дэлхийн эхлэлээс Бурханаас өгөгдөх тэдгээр бүх зүйл, түүнийг бэлэгдэх ажгуу.

5 Мөн түүнчлэн бидний өвөг дээдэстэй Их Эзэний хийсэн түүний “гэрээнд бодгаль минь баяснам; тийм ээ, үхлээс чөлөөлөх түүний агуу хийгээд мөнхийн төлөвлөгөөн дэх ач ивээл, мөн түүний шударга

ёс, мөн хүч, мөн нигүүлсэлд бодгаль минь баяснам.

6 Мөн Христ ирнэ, “үгүй бол бүх хүмүүн мөхөх ёстойг өөрийн хүмүүст нотлохдоо бодгаль минь баяснам.

7 Учир нь хэрэв Христ “үгүй бол Бурхан гэж үгүй; мөн хэрэв Бурхан үгүй аваас бид эс оршино, ⁶бүтээлт байж үл болохын учир бөлгөө. Гэвч Бурхан буй, мөн тэр бол Христ, мөн тэрээр өөрийн цаг хугацааны бүрэн байдалд ирэх болно.

8 Мөн эдүгээ миний хүмүүсээс эдгээр үгсийг уншсан хэн боловч тэдний зүрх сэтгэл хөөрч мөн бүх хүмүүний төлөө баясаж болохын тулд, би Исаиагийн зарим үгсийг бичих болно. Эдүгээ эдгээр нь тэрхүү үгс, мөн та нар тэдгээрийг өөрсөдтэйгөө мөн бүх хүмүүнтэй адилтгаж болох ажгуу.

БҮЛЭГ 12

Исаиа хожмын үеийн ариун сүм, Израилын цугларалт мөн Мянганы шүүлт болон энх амгаланг харав—Бардамнагчид ёс бусыг үйлдэгчид Хоёр дахь Ирэлтээр дорд үзэгдэх болно—Исаиа 2 дугаар бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мээ 559–545 он.

Иудей болон Иерусалимын

2б су Гэтэлгэгч.
3а 2 Ниф. 2:3;
Иаков 7:5.
б 2 Ниф. 27:12;
Ифер 5:2–4;
С ба Г 5:11.

4а Иаков 4:5;
Жером 1:11;
Алма 25:15–16;
Ифер 12:19.
б 2 Ниф. 31:2.
в 2 Ниф. 5:10.

5а су Абрахамын Гэрээ.
6а Мозая 3:15.
7а 2 Ниф. 2:13.
б су Бүтээх, Бүтээл.

талаар “үзсэн, Амосын хүү
^бИсаиагийн үг:

2 Мөнхүү улиран тохиох дор
эцсийн өдрүүдэд, Их Эзэний
“өргөөний ^буул нь “уулсын
оргил дээр баригдаж, мөн
толгодын дээр өргөгдөхөд
бүх үндэстнүүд үүнд цутган
ирэх болно.

3 Мөн олон хүмүүс явж мөн
хэлэх болно, Ирэгтүн та нар,
мөн Их Эзэний уул өөд,
Иаковын Бурханы өргөөнд
очицгооё; мөн тэрээр бидэнд
өөрийн замуудын талаар сур-
гах болно, мөн бид түүний
харгуйгаар “алхах болно; өө-
рөөр хэлбэл Сионоос ^бхууль,
мөн Их Эзэний үг Иерусали-
маас ундран гарах болой.

4 Мөн тэрээр үндэстнүү-
дийн дунд “шүүж, мөн олон
хүмүүнийг зэмлэх болно: мөн
тэд илдээ анжисны хошуу
болгон, мөн жаднуудаа ха-
суур болгон давтах болно—
үндэстэн үндэстнийхээ эсрэг
илд далайхгүй, бас тэд дайнд
дахин хэзээ ч суралцахгүй
байх болно.

5 Ай Иаковын угсаа, та
нар ирэгтүн мөн Их Эзэний

гэрэлд алхацгаая; тийм ээ,
ирэгтүн, учир нь та нар бүгд
“төөрч одсон, хүн бүр өөрийн
ёсон бус замуудад буюу.

6 Тиймийн тул, Ай Их Эзэн,
та өөрийн хүмүүсийг, Иако-
вын угсааг орхисон, учир юун
хэмээвээс тэд “филистинчүү-
дийн адил зөгнөн хэлэгчдийн
үгэнд орж, мөн тэд өөрсдий-
гөө гадныхны хүүхдүүдэд
^бтаацуулсан, дорнын нөлөө-
гөөр ^бдүүргэгдсэн болой.

7 Тэдний нутаг түүнчлэн
мөнгө болон алтаар дүүрэн,
бас тэдний эрдэнийн сан
төгсгөлгүй; тэдний нутаг
түүнчлэн морьдоор дүүрэн,
бас тэдний их тэрэгний нь
тоо төгсгөлгүй билээ.

8 Тэдний нутаг түүнчлэн
“хиймэл шүтээнүүдээр дүү-
рэн; тэд өөрсдийн хуруугаар
үйлдсэн тэдгээрийг, өөрсдийн
гарын бүтээлээ тэд шүтдэг.

9 Мөн ерийн хүн толгой “үл
бөхийж, мөн их хүн өөрийгөө
үл даруусгадаг, тиймийн тул,
түүнийг бүү өршөө.

10 Ай ёс бусыг үйлдэгчид та
нар, Их Эзэнээс айх айдас мөн
түүний сүр хүчний алдар суу

12 1a евр. Хаза гэдэг нь
үзэгдэл харах гэсэн
утгатай. Энэ нь
Исаиа Их Эзэнээс
ирсэн үзэгдлээр
дамжуулан уг
захиасыг хүлээн
авсан гэсэн утгатай.
б Исаиагийн 2-14
дүгээр бүлгүүдийг
2 Нифай 12-24-г
Нифай гуулин
ялтсуудаас иш
татжээ; энд үгээр
илэрхийлсэн зарим

ялгаа байгааг
анхаарах ёстой.
2a су Ариун Сүм, Их
Эзэний Өргөө.
б Иоел 3:17.
су Сион.
в С ба Г 49:25.
3a су Аллах, Бурхантай
хамт алхах.
б евр. Сургаал буюу
номлол.
4a 2 Ниф. 21:2–9.
5a 2 Ниф. 28:14;
Мозая 14:6;
Алма 5:37.

6a су Филистинчүүд.
б евр. Гараа сунгах,
эсвэл Гэрээ хийх.
в ө.х. Этгээд гажууд
заалаг зүйлүүд,
ийм итгэл
унэмшлээр
дуурсэн.
8a су Хиймэл шүтээн.
9a ө.х. Бурханд;
тэрээр түүний
оронд хуурамч
бурхдыг шүтэн
биширдэг.

та нарыг цохих учир хад чулуунд орогтун мөн өөрсдийгөө шороонд “нуу.

11 Мөнхүү улиран тохиох дор хүмүүний ихэмсэг төрх даруусгагдан, мөн хүмүүний ихэрхэг байдал доош гудайлгагдах болно, мөн тэр өдөр Их Эзэн ганцаараа өргөмжлөгдөх болно.

12 Учир нь Түмний Их Эзэний “өдөр удахгүй бүх үндэстнүүдийн дээр ирнэ, тийм ээ, тэд бүгдийн дээр; ^ббардам болон ихэмсгийн дээр, мөн хөөргөн болгоны дээр, мөн тэрээр дорд үзэгдэх буюу.

13 Тийм ээ, мөн Их Эзэний өдөр Ливаны бүх хуш моднууд дээр ирэх болно, тэдгээр нь өндөр мөн хөөрсний учир болой, мөн Башаны бүх царснууд дээр буюу;

14 Мөн бүхий л өндөр уулсын дээр, мөн бүх толгодын дээр, мөн хөөргөгдсөн тэдгээр бүх үндэстнүүдийн дээр, мөн ард түмэн бүрийн дээр;

15 Мөн өндөр цамхаг бүрийн дээр, мөн хашлагат хана бүрийн дээр;

16 Мөн “далайн бүхий л онгоцнуудын дээр, мөн Таршишийн бүх хөлөг онгоцнууд дээр, мөн бүх тааламжтай сайхан дүрслэлүүд дээр буюу.

17 Мөн хүмүүний ихэмсэглэл доош гудайлгагдаж, мөн хүмүүний ихэрхэг байдал дорд үзэгдэх болно; мөн “тэр өдөр Их Эзэн ганцаар өргөмжлөгдөх болно.

18 Мөн хиймэл шүтээнүүдийг тэрээр бүрмөсөн үгүй хийх болно.

19 Мөн тэд хадны хонгилд, мөн газрын агуйд хоргодох болно, тэрээр газар дэлхийг аймшигтайгаар сэгсрэхээр босоход Их Эзэнээс айх айдас тэдний дээр ирнэ, мөн түүний сүр жавхлангийн их нь тэднийг цохихын учир болой.

20 Тэр өдөр хүмүүн өөрийн мөнгөн шүтээнийг, мөн өөрийн алтан шүтээнийг, тэрээр шүтэхийн тулд өөртөө хийсэн тэдгээрийг, сохор номин болон сарьсан багваахайд “хаях болно.

21 Хадны нөмөрт, мөн барзгар хадны оройд очно, учир нь тэрээр газар дэлхийг аймшигтайгаар сэгсрэхээр босоход Их Эзэнээс айх айдас тэдний дээр ирнэ, түүний сүр жавхлангийн их нь тэднийг цохихын учир болой.

22 Та нар хамрынхаа нүхэнд амьсгалах тэр, “хүмүүнд хандахаа боль, түүнийг юуны учир хүндэтгэнэ вэ?

10a Алма 12:14.

12a су Есүс Христийн Хоёр дахь Ирэлт.

б Малах. 4:1;

2 Ниф. 23:11;

С ба Г 64:24.

16a Грек (Септуагинт) хувилбарт еврей хэлний хувилбарт

байдаггүй нэг, еврей хувилбарт грек хэлэн дээрх хувилбарт байдаггүй нэг өгүүлбэр байдаг; гэвч 2Ниф. 12:16-д хоёул байдаг.

17a ө.х. Их Эзэн алдар

суунд залран ирэх тэрхүү өдөр.

20a евр. Хаях.

22a ө.х. Мөнх бус хүмүүнд найдахаа болих, Бурхантай харьцуулахад тэрээр бага хүчтэй.

БҮЛЭГ 13

Иудей болон Иерусалим дуулгаваргүй байдлынхаа улмаас шийтгэгдэх болно—Их Эзэн өөрийн хүмүүсийг өмгөөлж мөн шүүх бөлгөө—Сионы охид шунал тачаалынхаа улмаас зүхэгдэж бас зовоогдох болно—Исаиасгийн 3 дугаар бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мэв 559–545 он.

Учир нь болгоогтун, Их Эзэн, Түмний Их Эзэн, зайлуулан авах болой, Иерусалимаас, мөн Иудейгаас, түших тулгуурыг мөн таягийг, талх болох бүтэн таягийг нь ч, мөн ус болох бүтэн тулгуурыг ч буюу—

2 Чадалтай хүнийг, мөн дайнч хүнийг, шүүгч, мөн бошиглогч, мөн хашир сэрэмжтэй нэгнийг, мөн ахмад нэгнийг;

3 Тавийн ахмад, мөн хүндэт нэгэн, мөн зөвлөх, мөн уран дархан, мөн уран илтгэгчийг.

4 Мөн би хүүхдүүдийг тэдний ханхүү байхаар тэдэнд өгөх болно, мөн нялхас тэдний дээр захирах болно.

5 Мөн хүмүүс нэг нь нөгөөгөөрөө, мөн хүн бүр хөршүүдээрээ дарамтлуулах болно; хүүхэд өөрийгөө ахмад нэгний эсрэг дээгүүрт тавин бардамнах буюу, мөн адгийн муу нь хүндэт нэгний эсрэг болой.

6 Хүн эцгийнхээ отгийнх болох ахдаа хэлэх нь: Танд хувцас буй, та бидний захирагч бол, мөн таны мутрын дор энэхүү “устгал мөхөл бүү халдаг—

7 Тэр өдөр тэрээр тангараглаж, хэлэх нь: би “эдгээгч байх нь үгүй; учир нь миний гэрт талх ч, хувцас ч алга; хүмүүсийн захирагч бүү болго намайг.

8 Учир нь Иерусалим “балгас болсон, мөн Иудей “унасан болой, тэдний хэл ам, хийсэн үйлүүд Их Эзэний эсрэг байсан нь, түүний сүр жавхлант мэлмийг өдөөн уурлуулсны учир бөлгөө.

9 Тэдний төрх байдал тэдний эсрэг гэрчилж, мөн тэдний нүгэл бүр “Содомын адил болохыг тунхагласан ажгуу, мөн тэд үүнийгээ далдалж чадахгүй. Тэдний бодгалиудад халаг, тэд хилэнцийг өөрсөддөө шагнал болгосны учир болой.

10 Тэдэнд “сайн болохыг зөв шударгыг үйлдэгчдэд хэл; учир нь тэд үйлүүдийнхээ үр жимсийг хүртэх болно.

11 Ёс бусыг үйлдэгчдэд халаг, учир нь тэд мөхөх болно; тэдний гарын шагнал тэдний дээр байх болно!

12 Мөн миний хүмүүсийг, хүүхдүүд тэдний дарлагчид байж, эмэгтэйчүүд тэднийг захиран удирдах болно. Ай

13 ба Иса. 3:6.

7а Евр. Боох (шарх);
ө.х. би чиний
асуудлуудыг
шийдэж чадахгүй.

8а Иер. 9:11.

б Сол. дуул. 1:3.
9а Эхл. 19:1, 4–7, 24–25.
сү Ижил
хүйстэнтэйгээ

бэлгийн харьцаанд
орох.

10а Дэд хууль 12:28.

хүмүүс минь, та нарыг “удирдаж буй тэд та нарыг буруут болгосон мөн та нарын замнах замыг устгадаг бөлгөө.

13 Их Эзэн “өмгөөлөхөөр босно, мөн хүмүүсийг шүүхээр босох болно.

14 Их Эзэн өөрийн хүмүүсийн эртнийхэн мөн тэдний “хан хөвгүүдтэй шүүхэд заалдах болно; учир нь та нар ^бядуугийн ^аталбайг мөн ядуугийн ^ххөрөнгийг өөрсдийнхөө гэрт ^дидэж дуусгасан билээ.

15 Та нар ямар учиртай билээ? Та нар миний хүмүүсийг тасчдаг, мөн ядуугийн нүүрийг няцалдаг хэмээн Түмний Их Эзэн Бурхан хэлэх буюу.

16 Үүнээс гадна, Их Эзэн хэлдэг: Сионы охид ихэмсэг, мөн хүзүү сунган завхай харц чулуудан алхалж, явахдаа “сайварлан, мөн хөлөн дэх хонхоо жингэнүүлэн алхдаг —

17 Тиймийн тул Их Эзэн Сионы охидын зулайг яр шарханд бариулж мөн Их Эзэн тэдний нууц хэсгүүдийг нь “ил харуулах болно.

18 Тэр өдөр Их Эзэн тэдний хангинан жингэнэх чимгүүдийн мөн “үсний тор, мөн сар адил ^бдугираг гархинуудын тансаг үзэмжийг нь булаан авах болно;

19 Шаргих гинжнүүд мөн бугуйвчнууд, мөн “хүзүүний ороолтуудын;

20 Товь малгайнууд, мөн хөлийн чимгүүд, мөн толгойн алчуурууд, мөн пайзнууд, мөн ээмэгнүүдийн;

21 Бөгжнүүд, мөн хамрын гоёлуудын;

22 “Сольж өмсөх хувцасны зүйл, мөн нөмрөг, мөн толгойн бүрх, мөн үсний хатгууруудын;

23 “Шил толинууд, мөн нарийн нэхээст эд, мөн юүдэн, мөн гивлүүрүүдийн буюу.

24 Мөнхүү улиран тохиох дор, сайхан үнэрийн оронд эхүүн үнэр ханхална; мөн бүсний оронд “даавууны тасархай; мөн сайхан үсний оронд халзрал; мөн ^бцээживчний оронд самбай даавуу; “түлэгдсэн шарх гоо сайхны нь оронд байх буюу.

25 Чиний эрс илдэнд мөн

12а Иса. 9:16.

13а евр. Тэмцэх.

Мика 6:2;

С ба Г 45:3–5.

14а евр. Захирагчид буюу удирдагчид.

б 2 Ниф. 28:12–13.

в Иса. 5:7.

г ө.х. өмч хөрөнгө идэж шамшигдуулах.

д евр. Шатах буюу түлэгдэх.

16а ө.х. Сайварлан алхах, сээтгэнүүр байдалтай

хурдан алхах.

17а евр. Ил тавих; хэлц утга нь “тэднийг ичээх” “тэднийг ичгүүрт тавих”.

18а Үсний тор байж болзошгүй. Шүлэг 18-23-т нэрлэсэн эмэгтэйчүүдийн гоёл чимэглэлүүдийн уг мөн чанарыг эрх баригчид ямагт хүлээн зөвшөөрдөггүй байжээ.

б ө.х. Хавирган сар лугаа адил хэлбэртэй хээ угалз.

19а евр. Хөшигнүүд.

22а евр. Гоёмсог хувцаснууд.

23а эсвэл Нэвт гэрэлтсэн хувцаснууд.

24а евр. Даавууны өөдөс.

б эсвэл Орхимж,

нөмрөг.

в эсвэл Тамга (боолын тэмдэг).

чиний хүчтэнүүд дайнд унах болно.

26 Мөн хотын хаалганууд газлан чохарч; мөн хот нь балгас болон эзгүйрч, мөн тэр хөсөр суух болно.

БҮЛЭГ 14

Сион болон түүний охид Мянганы өдөр гэтэлгэгдэж мөн цэвэршигдэх болно—Исаиа 4 дүгээр бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мээ 559–545 он.

Мөн тэр өдөр, долоон эмэгтэй нэг эрийг барьж, хэлэх нь: бид өөрсдийнхөө талхыг идэж, мөн өөрсдийн хувцсыг өмсөх болно; зөвхөн таны нэрээр нэрлэгдэж “шившгээ зайлуулахыг бидэнд зөвшөөрөөч гэгцгээх болно.

2 Тэр өдөр Их Эзэний “мөчир гоо үзэсгэлэнтэй мөн сүр жавхлантай байх болно; Израилаас зугтаж чадсан тэдэнд дэлхийн жимс онцгой сайн мөн дур булаам байх болно.

3 Мөнхүү улиран тохиох дор, Сионд хоцорч мөн Иерусалимд үлдсэн тэд ариун гэж нэрлэгдэх болно, Иерусалимд амьд үлдэгсдийн дунд бичигдсэн хүн бүр буюу —

4 Их Эзэн Сионы охидын бузар буртгийг “угаан арил-

гасны дараа мөн Иерусалимын цусыг тэдний дундаас шүүлтийн суу билгээр мөн дүрэлзэх суу билгээр ариутгасны дараа болой.

5 Мөн Их Эзэн Сионы уулын оршин байх нутаг бүрийн дээр, мөн түүний чуулгануудын дээр, өдөр нь “үүл манан болон утаа, мөн шөнө нь дүрэлзэх галын гэрлийг бүтээнэ; учир нь Сионы бүх алдар суугийн дээр хамгаалал байх болно.

6 Мөн өдөр нь халуунаас сүүдэрлэхийн тулд, мөн “хоргодох газар байхын тулд, мөн шуурга борооноос халхлахын тулд асар байх болно.

БҮЛЭГ 15

Их Эзэний талбай (Израил) зэлүүд болж, мөн түүний хүмүүс тараагдах болно—Тэдний урвалт мөн тараагдалтад халаг нь тэдний дээр ирэх болно—Их Эзэн далбаа өргөж мөн Израилыг цуглуулах болно—Исаиа 5 дугаар бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мээ 559–545 он.

Мөн тэгээд миний ихэд хайрлах түүнд өөрийн хайртын, түүний талбайн тухай “дууг дуулах буюу. Миний ихэд

14 1а ө.х. Нөхөрт гараагүй буюу хүүхэдгүйн улмаас муу нэртэй байх.
2а Иса. 60:21;
2 Ниф. 3:5;
Иаков 2:25.
4а су Угаах, Угаагдах, Угаалга.

б ө.х. Их Эзэн газар дэлхийг цэвэршүүлсэн үед.
в Малах. 3:2–3; 4:1.
5а Ег. 13:21.
6а Иса. 25:4;
С ба Г 115:6.
15 1а ө.х. Бурханы нигүүлсэл болон

Израилын хариуцлагаа ухамсарлаагүй харуулан, бошиглогч дуу буюу шүлэглэсэн сургаалт үгс зохиодог байжээ.

хайрлах түүнд үржил шимт толгойд талбай буй.

2 Мөн тэрээр үүнийг хүрээлэн, мөн чулуунуудыг нь цуглуулан зайлуулж, мөн үүнд хамгийн шилмэл ороонгыг “тариалсан, мөн үүний дунд цамхаг барьж, мөн түүнчлэн тэнд дарс шахагчийг хийсэн; мөн тэрээр энэ нь усан үзмийг өгөх буюу хэмээн харсан, мөн энэ нь зэрлэг усан үзмийг ургуулсан болой.

3 Мөн эдүгээ, Ай Иерусалимын оршин суугчид, мөн Иудейн эрс, би болон миний талбайн дундах маргааныг шүүгээч, би танаас гуйя.

4 Ямар зүйлийг би илүүгээр өөрийн усан үзмийн талбайд хийж болох байсныг би эс хийсэн билээ? Иймийн тул, би энэ нь усан үзэм өгнө хэмээн харж байхад зэрлэг усан үзэм өгсөн билээ.

5 Мөн эдүгээ яв; би талбайгаа яахыг та нарт хэлье—би үүний хашаа хүрээг “зайлуулна, мөн энэ нь идэгдэж устгагдах болно; мөн би үүний ханыг хэмхлэн буулгана, мөн энэ нь гишгэгдэх болно;

6 Мөн би үүнийг хөсөр орхисон ажгуу; энэ нь засагдаж бас сийрүүлэгдэхгүй болой; харин тэнд “хатгуур мөн өргөснүүд ургах болно; түүнчлэн би үүлнүүдэд тэд үүний

дээр ⁶хур бороо оруулахгүй байхыг зарлиглах болно.

7 Өөрөөр хэлбэл Түмний Их Эзэний “талбай нь Израилын угсаа бөлгөө, мөн Иудейн эрс түүний тааламжит ургамал буюу; мөн тэрээр зөв шударга ⁶шийдвэрийг эрсэн боловч, харин түрэмгийллийг нь болгоогтун; зөв шударгыг эрэх хэдий ч, гэвч гаслан уйлахыг болгоогтун.

8 Энэ хорвоогийн дунд “ганцаар байрлуулагдаж болохын тулд, зайгүй болтол, ⁶байр байрыг нэгтгэх тэдэнд халаг!

9 Түмний Их Эзэн хэлэв, миний сонорт үнэхээр олон байшин орхигдож, мөн агуу болоод үзэсгэлэнт хотууд оршин суугчидгүй болно хэмээв.

10 Тийм ээ, арван акр усан үзмийн талбай нэг “хөнөг ургац өгөх бөлгөө, мөн ган дүүрэн үрээс торх ургац авах болно.

11 Хүчит ундааг “хайхын тулд, өглөө эртлэн босч мөн шөнө болтол үргэлжлүүлнэ, ⁶дарс тэднийг мансууруулах тэдэнд халаг!

12 Мөн босоо ятга, мөн пийпаа, хэц хэнгэрэг, мөн цоор хөгжим бас дарс тэдний найран дээр байдаг; харин тэд Их Эзэний үйлийг “үл хүндлэн, мөн түүний мутраар

2а Иер. 2:21.

5а Дуул. 80:12.

6а Иса. 7:23; 32:13.

б Иер. 3:3.

7а су Их Эзэний талбай.

б эсвэл Шударга ёс.

8а ө.х. Ганцаар

амьдрахаар

орхигдох. Газрын

баян чинээлэг эзэд

ядуусын жижиг

фермүүдийг

залгидаг.

б Мика 2:1–2.

10а Езек. 45:10–11.

11а Сур. үгс 23:30–32.

б су Мэргэн Ухааны Үг.

12а Дуул. 28:5.

үйлдэгдсэнийг ч анхаарах нь үгүй болой.

13 Тиймийн тул, миний хүмүүс тэд “мэдлэггүйн учир боолчлолд хүрсэн болой; мөн тэдний хүндэт иргэд ч өлсөж гуринхлан, мөн тэдний ардууд цангаснаас хатсан буюу.

14 Тиймийн тул, там өөрийгөө томгосон, мөн амаа хэмжээгүй ихээр ангайж; мөн тэдний алдар суу, мөн тэдний ард олон, мөн тэдний сүр жавхлан, мөн баясах тэрээр үүнд доош орох болно.

15 Мөн ердийн нэгэн дорд үзэгдэж, мөн хүчит нэгэн даруу болгогдох болно, мөн ихэмсэг нэгний харц даруу болгогдох болно.

16 Гэвч Түмний Их Эзэн “шүүлтэд өргөмжлөгдөх болно, түүнчлэн ариун Бурхан зөв шударга ёсонд ариусгагдах болно.

17 Чингээд хурганууд өөрсдийн тааваар тэжээгдэн, мөн тэжээгдэж бордогдсон тэдний орхисон нутгуудад гадныхан идээшлэх болно.

18 “Дэмий хоосны оосроор алдсыг, мөн тэрэгний жолоогоор ⁶мэт нүглийг чирэх тэдэнд халаг;

19 Бид үүнийг харж болохын тулд, тэр “яараг, ажлаа амжуулаг; мөн бид үүнийг ⁶мэджэ болохын тулд Израилын Ариун Нэгэний зөвлөгөө ойртож мөн ирэг хэмээн хэлэх тэдэнд буюу.

20 Сайныг муу “гэх, мууг сайн гэх тэдэнд, мөн гэрлийг ⁶харанхуйгаар орлуулах, гэх тэдэнд, гашуунаар амттайг, мөн амттайгаар гашууныг орлуулах тэдэнд халаг!

21 Өөрсдийнхөө нүдэнд “ухаалаг болох тэдэнд мөн өөрсдийн нүдэнд хашир гэгдэх тэдэнд халаг!

22 Дарс уухдаа хүчтэй, мөн хүчит ундааг холихдоо чадалтай хүмүүнд халаг;

23 Ёсон бусыг үйлдэгчдийг шагнуулахын тулд зөвтгөх, мөн зөв шударга хүмүүний зөв шударга үйлийн баталгааг түүнээс “булаан авах тэдэнд буюу!

24 Тиймийн тул, “талбайд үлдсэн сүрэлд гал авалцахын, мөн ⁶тарианы хальс хогонд ⁶дөл тархахын адилаар, тэдний үндэс өмхрөх болно, мөн тэдний дэлбээ тоос лугаа адил хатах буюу; учир юун хэмээвээс тэд Түмний Их Эзэний хуулийг хаяж, мөн

13a Хосеа 4:6.

су Мэдлэг.

16a су Есүс Христ—
Шүүгч.

18a су Хоосон үг,
Хоосон үг ярих.

б ө.х. Амьтад ачаандаа хүлэгдсэн лугаа адил тэд нүгэлдээ хүлэгдсэн байдаг.

19a Иер. 17:15.

б ө.х. Мессиаг харах хүртлээ тэд түүнд итгэхгүй байх болно.

20a Моро. 7:14, 18;

С ба Г 64:16; 121:16.

б 1 Иохан 1:6.

21a Сур. үгс 3:5–7;

2 Ниф. 28:15.

23a ө.х. Түүний иргэний

эрхийг хасах.

24a Иоел 2:5;

1 Ниф. 22:15, 23;

2 Ниф. 26:4, 6;

С ба Г 64:23–24;

133:64.

б Лук 3:17;

Мозая 7:29–31.

в Обад. 1:18;

Малах. 4:1–2;

2 Ниф. 20:17.

Израилын Ариун Нэгэний үгийг ‘зэвүүцсэн болой.

25 Тиймийн тул, Их Эзэний “уур өөрийн хүмүүсийн эсрэг дүрэлзэж, мөн тэрээр мутраа тэдний эсрэг сунгаж, мөн тэднийг цохьсон бөлгөө; мөн толгод чичирч, мөн тэдний цогцсууд гудамнуудын дунд урж тасдагдсан буюу. Энэ бүгд байсан ч, уур нь зайлуулагдаагүй, харин ч түүний мутар далайсан хэвээр бөлгөө.

26 Мөн тэрээр алс холын үндэстнүүдэд “далбаа өргөж, мөн дэлхийн хязгаарыг хүртэл тэдэнд ‘исгэрэх болно; мөн болгоогтун, тэд хурдлан яарч “ирэх болно; тэдний дунд ядрах, бүдрэх нэгээхэн ч үгүй байх болно.

27 Нэгээхэн ч болов нойрмог унтамхай байхгүй; басхүү тэдний хэвлийдээ бүсэлсэн нь алдуурахгүй, тэдний шаахайн сур нь ч тасрахгүй;

28 Сум нь хурц байх тэдний, мөн тэдний бүх нумнууд нь хөвчлөөстэй, мөн тэдний морьдын туурай цахиур чулуу лугаа адил тооцогдох болно, мөн тэдний тэрэг нь хуй салхи мэт, тэдний архиралт нь арслан лугаа адил байх бөлгөө.

29 Тэд залуу “арслан лугаа адил архирах болно; тийм ээ, тэд архиран, мөн олзыг

барьж, тэгээд аюулгүйгээр зайлуулан зөөх болно, мөн хэн ч чөлөөлөхгүй.

30 Мөн тэр өдөр тэд хүрхрэх далай мэт тэдний эсрэг архирах болно; мөн хэрэв тэд газрыг харах аваас, болгоогтун, харанхуйлал бас харамсал, мөн гэрэл нь тэнгэртээ харласан байх болно.

БҮЛЭГ 16

Исаиа Их Эзэнийг харав — Исаиагийн нүглүүд өршөөгдөв — Тэрээр бошиглохоор дуудагдсан буюу — Тэрээр Христийн заадаг зүйлүүдээс иудейчүүд татгалзахыг бошиглов — Үлдэгдэл эргэж ирэх болно — Исаиа 6 дугаар бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мээ 559–545 он.

Узиа хаан нас нөгчсөн тэр “жил, Их Эзэн сэнтий дээр залран буйг би түүнчлэн үзсэн, өндөрт мөн өргөгдсөн, мөн түүний “хормой ариун сүмийг дүүргэсэн болно.

2 Үүний дээгүүр “серафимууд зогсоно; тус бүр нь зургаан далавчтай бөлгөө; тэрээр хоёроор нь нүүрээ халхалж, мөн тэрээр хоёроор нь хөлөө халхалж, мөн тэрээр хоёроор нь нисдэг авай.

3 Мөн нэг нь нөгөөдөө хашгиран, ийн хэлэв; Түмний Их Эзэн ариун, ариун, ариун; бүх

24г 2 Сам. 12:7–9.

25а С ба Г 63:32;

Моисе 6:27.

26а су Туг.

б эсвэл Шүгэл; ө.х.

цугларах дохио.

Иса. 7:18;

2 Ниф. 29:2.

в су Израил—

Израилын цугларалт.

29а 3 Ниф. 21:12–13.

16 1а ө.х. мээ 750 оны

орчимд.

б ө.х. Түүний

өмсгөлийн зах

эсвэл уг өмсгөлийн эмжээр.

2а су Херубим.

дэлхий түүний алдар суугаар дүүрэн болой.

4 Мөн үүдний “баганууд түүний хашгирах дуугаар зайлж, мөн барилга утаагаар дүүргэгдсэн бөлгөө.

5 Чингээд би хэлэв: Надад халаг! Би “устгагдсаны улмаас болой; учир нь би цэвэр бус уруултай хүн; мөн цэвэр бус уруултай хүмүүсийн дунд би оршдог; миний нүд Хааныг, Түмний Их Эзэнийг харсны учир бөлгөө.

6 Чингээд серафимуудын нэг нь галын хайчаар өргөлийн тавцан дээрээс өөрийн авсан, ноцож буй “цогийг гартаа аван, над уруу нисч ирэв;

7 Мөн тэрээр үүнийг миний аманд хүргээд, мөн хэлэв: Үз, энэ нь таны уруулд хүрсэн; мөн таны “алдас зайлуулагдсан, мөн таны нүгэл ариусгагдсан.

8 Түүнчлэн, хэнийг би илгээх билээ; мөн хэн бидний төлөө явах билээ? хэмээх Их Эзэний дууг би сонсов. Чингээд би хэлэв: Би энд байна; намайг илгээ.

9 Мөн тэрээр хэлсэн нь: Яв мөн энэ хүмүүст хэл — Үнэндээ та нар сонсогтун, гэвч тэд ойлгосонгүй; мөн үнэндээ та нар харагтун, гэвч тэд ухаарсангүй.

10 Энэ хүмүүсийн зүрхийг

хөшүүн болго, бас тэдний чихийг хатуу болго, мөн тэдний нүдийг хаа — тэд өөрсдийн нүдээр харж, мөн чихээрээ “сонсож, мөн зүрх сэтгэлээрээ ойлгож, мөн өөрчлөгдөн эргэж мөн эдгээгдэх вий хэмээв —.

11 Чингээд би хэлэв: Их Эзэн, хэр удаан билээ? Мөн тэрээр хэлсэн нь: Хотууд оршин суугчидгүй эзгүйрч, мөн байшингууд хүнгүй, мөн газар нутаг бүрмөсөн зэлүүд болох хүртэл;

12 Мөн Их Эзэн хүмүүсийг алс хол “нүүлгэх болой, агуу их эзгүйрэл уг нутагт байхын учир бөлгөө.

13 Гэвч тэр үед арваас нэг нь үлдэх болно, мөн тэд эргэж ирэх болно, мөн навчсаа гэсэн ч гол нь амьд байх далдуу лугаа адил, мөн царс лугаа адил идэгдэх болно; тийн ариун үр түүний “амь байх болно.

БҮЛЭГ 17

Ефраим болон Сири Иудейн эсрэг дайн өдөөв — Христ онгон бүсгүйгээс төрөх болно — Исаиагийн 7 дугаар бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мээ 559–545 он.

Мөнхүү улиран тохиох дор Уззиагийн хүү болох Иофа-

4a евр. Босгын суурь чичрэв.

5a евр. Тусгаарлагдах; ө.х. өөрийн хийгээд өөрийн хүмүүсийн нүглүүдийг ухамсарлан ойлгосноор тэрээр

дийлэгдсэн байв.

6a ө.х. Цэвэршилтийн бэлэгдэл.

7a су Нүглүүдийн ангижрал.

10a Мат. 13:14–15.

12a Хаад, дэд 17:18, 20.

13a ө.х. Мод лугаа адил,

хэдийгээр модны навчнууд тайрагдсан ч амьдрал болон үр өгөх чадавхи нь үүнд хадгалагдсаар байдаг.

мын хүү Иудейн хаан Ахазын өдрүүдэд, Сирийн хаан болох тэр Резин, мөн Ремалиагийн хүү Израилын хаан Пека, Иерусалимын эсрэг дайтахаар түүнийг зүг одов, гэвч үүнийг ялж эс чадав.

2 Мөн энэ нь Давидын угсаанд хэлэгдсэн бөлгөө, хэлрүүн: Сири нь “Ефраимтай хуйвалдах болой. Мөн түүний зүрх сэтгэл хөдөлсөн, мөн түүний хүмүүсийн зүрх, ургаа мод салхинд хөдөлдөг лугаа адил бөлгөө.

3 Чингээд Их Эзэн Исаиад хэлэв: Ахазтай уулзахаар эдүгээ урагш од, та болон таны хүү “Шиержашуб, угаагчийн талбайн их замд байх дээд усан сангийн сувгийн төгсгөл тийш буюу.

4 Мөн түүнд хэл: Болгоомжтой бай, мөн нам гүм бай, эдгээр утаа манарах галт цуцлуудын хоёр үзүүрээс “бүү эмээгтүн, бас битгий зүрх алд, Сирийн Резин мөн түүний хүү Ремалиа нарын догшин хилэнгийн учир бөлгөө.

5 Учир нь Сири, Ефраим мөн Ремалиагийн хүү таны эсрэг ёс бус зөвлөлдөв, үүнд:

6 Бүгдээр Иудейн эсрэг явж, мөн түүнийг өдөөе, мөн үүнд өөрсдийн төлөө эвдрэлийг “үүдэж, мөн үүний дунд хаан

тохооё, тийм ээ, Табиелын хүүг буюу.

7 Их Эзэн Бурхан ийн хэлэв: Энэ нь бүтэхгүй, мөн улиран тохиох нь ч үгүй болой.

8 Тухайлбал Сирийн тэргүүн Дамаск, мөн Дамаскийн тэргүүн Резин; мөн жаран таван жилд Ефраим улс үгүй болж эвдлэгдэх бөлгөө.

9 Мөн Ефраимын тэргүүн Самари, мөн Самарийн тэргүүн нь Ремалиагийн хүү билээ. Хэрэв та нар “итгэхгүй аваас, та нар хамгаалагдахгүй нь магад.

10 Үүнээс гадна, Их Эзэн Ахазад дахин ярьж, хэлсэн нь:

11 Их Эзэн, Бурханаасаа нэгэн “тэмдэг гуй; гүн гүнзгийг, эсвээс дээр өндөрт үүнийг гуй.

12 Харин Ахаз хэлэв: Би гуйх нь үгүй, бас Их Эзэнийг би “сорих нь үгүй.

13 Мөнхүү тэрээр хэлэв: Эдүгээ та нар сонс, Ай Давидын угсаа; хүмүүнийг ядраах нь та нарт бага зүйл үү, харин та нар түүнчлэн Бурханыг минь ядраах гэж үү?

14 Тиймийн тул, Их Эзэн өөрөө та нарт тэмдэг өгөх болно — Болгоогтун, “онгон бүсгүй хөл хүндтэй болно, мөн хүү төрүүлж, мөн түүний нэрийг ⁶Иммануел гэж дуудах болно.

17 2а ө.х. Умардын бүх Израил нь умардын тэргүүлэх овог Ефраимын нэрээр нэрлэгддэг байжээ.

3а евр. Үлдэгсэд эргэж ирэх болно.

4а ө.х. Дайралтад түгшүүрлэх хэрэггүй; энэ хоёр хаанд багахан гал үлдсэн ажгуу.

6а евр. Үүнийг хуваа.

9а Шаст. дэд 20:20.

11а су Тэмдэг.

12а ө.х. Сорих, хичээх эсвэл нотлох.

14а су Онгон.

б евр. Бидэнтэй хамт байгаа нь Бурхан болой.

су Иммануел.

15 Тэрээр цөцгийн тос, бал иднэ, тэр хилэнцтээс татгалзаж мөн сайныг сонгохыг мэдэж болохын тулд буюу.

16 Учир нь уг “хүүхэд хилэнцтээс татгалзаж мөн сайныг сонгож мэдэхээс урьд, таны жигшдэг тэр нутаг, хоёр хаанд ^бхоёуланд нь хаягдах болно.

17 Их Эзэн таны дээр, мөн таны хүмүүсийн дээр, мөн таны эцгийн отгийн дээр “Ефраим Иудейгаас зайлсан тэр өдрөөс хойш ирээгүй тэр өдрүүдийг, Ассирийн хааныг ^бавчрах болно.

18 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Египетийн хамгийн алс хэсэг дэх ялааг, мөн Ассирийн нутаг дахь зөгийг “исгэрэн дуудах болно.

19 Мөн тэд ирэх болно, мөн тэд бүгд ээлүүд хөндийн дээр, мөн хадны хонгилд, мөн бүх өргөс, мөн бүх бутнуудын дээр амсхийх болно.

20 Мөн тэрхүү өдөр Их Эзэн голын цаадах тэднээр, Ассирийн “хаанаар хөлслөгдсөн сахлын хутгаар, толгойг, мөн хөлийн үсийг ^бхусуулах болно; мөн энэ нь түүнчлэн сахлыг ч авах болно.

21 Мөнхүү улиран тохиох дор тэр өдөр, нэгэн хүн залуу үнээ мөн хоёр хонийг “тэжээх болно.

22 Мөнхүү улиран тохиох дор, тэдгээрийн өгөх элбэг их сүүний тул тэрээр цөцгийн тос идэх болно; өөрөөр хэлбэл цөцгийн тос болон балыг уг нутагт үлдсэн хүн бүр идэх болно.

23 Мөнхүү улиран тохиох дор тэр өдөр, мянган “мөнгөн зоосны үнэ бүхий, мянган усан үзмийн ороонго байсан тэнд, газар бүрд өргөст бут мөн хатгуур байх болно.

24 Хүмүүс нь нум сум агсан тэнд ирэх болно, бүх нутаг өргөст бут болон хатгуур болохын учир болой.

25 Мөн зээтүүнд сэндийлэгдэх бүх толгодод, тэнд өргөст бут болон хатгуураас айх айдас байх нь үгүй; харин энэ нь шар үхэр туух газар, мөн “бага малын бэлчээр байх болно.

БҮЛЭГ 18

Христ тээглэх чулуу лугаа адил дургүйцлийн хад мэт байх болно—Бувтналдах илбэчдийг бус, Их Эзэнийг хайцгаа—Удирдамжийн төлөө хууль мөн гэрчлэлийн зүг эргэцгээ—Исаиа 8 дугаар бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мээ 559–545 он.

Үүнээс гадна, Их Эзэний үг надад хэлсэн нь: Их ботийг

16a 2 Ниф. 18:4.

^б Хаад. дэд 15:30; 16:9.

17a Хаад. дээд 12:16–19.

^б Шаст. дэд 28:19–21.

18a эсвэл Шүгэл; ө.х.

дохио, зарлан
дуудах бичиг.

Иса. 5:26.

20a Хаад. дэд 16:5–9.

^б ө.х. Харийн булаан
эзлэгчид газар
нутгийг нь
эзгүйрүүлэх болно.

21a ө.х. Өөрийгөө

хамгаалах
чадвартай хэдхэн
амь гарагч л үлдэх
болно.

23a эсвэл мөнгөн зоос.

25a Евр. Хонь, эсвэл
ямаа.

ав чи, мөн хүмүүний үзгээр үүн дээр бич, “Махер-шалал-хаш-базын талаар буюу.

2 Мөн би өөртөө итгэлтэй “гэрчүүдийг цэдгүүд хөтлүүлэхээр авсан бөлгөө, санваартан Уриа, мөн Иебе-рекиагийн хүү Зехариаг буюу.

3 Мөн би “бошиглогч эмэгтэйд очив; мөн тэрээр бие давхар болж мөн хүү төрүүлэв. Чингээд Их Эзэн надад хэлэв: Түүний нэрийг Махер-шалал-хаш-баз хэмээн дууд.

4 Учир нь болгоогтун, Дамаскийн баялаг болон Самарийн “олз Ассирын хааны өмнө аваачигдахаас урьд уг ^бхүүхэд аав минь, мөн ээж минь гэж хашгирах “мэдлэггүй байх болой.

5 Их Эзэн түүнчлэн надад дахин ярьж, хэлсэн нь:

6 Энэ хүмүүс зөөлөн урсгалт “Шилогийн уснаас татгалзана, мөн ^бРезинд болон Ремалиагийн хүүд баясахын хэрээр буюу;

7 Эдүгээ тиймийн тул, болгоогтун, Их Эзэн “тэдний дээр голын хүчит их усыг авчирна, бүр Ассирийн хаанмөн түүний бүх сүр жавхланг буюу; мөн энэ нь

бүх суваг шуудуугаа хальж, мөн бүх эргээ даван ирэх болно.

8 Мөн тэрээр Иудейг “гатлах болно, энэ нь үерлэж мөн халих болно, энэ нь бүр хүзүүгээр татах болно; мөн үүний хаялах давалгаа нутгийн чинь энг дүүргэх болно, Ай ^бИммануел.

9 Өөрсдийгөө “нэгтгэцгээ, Ай хүмүүс та нар, мөн та нар хэдэн хэсэг тасчигдах болно; мөн алс нутгийн та нар бүгд чих тавьцгаа; өөрсдийгөө хуяглацгаа, мөн та нар хэдэн хэсэг тасчигдах болно;

10 Хамтран зөвлөцгөө, мөн энэ нь юунд ч хүргэхгүй болой; үг хэлэлц, мөн энэ нь тогтсоноор болохгүй; “учир нь Бурхан бидэнтэй хамт байгаа.

11 Учир нь Их Эзэн чингээд надад хүчтэйгээр ярьж мөн би энэ хүмүүсийн замаар алхах ёсгүйг надад зааварлан, хэлсэн нь:

12 Та нар энэ хүмүүсийн “Хуйвалдаан гэж хэлэх тэр бүгдэд Хуйвалдаан хэмээн бүү хэл; тэдний айснаас бүү ай, бас бүү эмээгтүн.

13 Түмний Их Эзэнийг өөрийг нь алдаршуулцгаа, мөн та нарын “айдас тэр байг,

18 1а ө.х. Устгал зайлшгүй.
2а су Гэрч.
3а ө.х. түүний эхнэр.
4а Хаад. дэд 15:29.
б 2 Ниф. 17:16.
в Иса. 8:4.
6а Эхл. 49:10; исо, Эхл. 50:24.
б Иса. 7:1.
7а ө.х. Эхлээд умард

Израил дээр.
8а ө.х. Тэрчлэн Ассири Иудейд халдах болно.
б су Иммануел.
9а ө.х. Холбоод үүсгэн бий болгох.
10а ө.х. Иудей (Иммануэлийн нутаг) хэлтрүүлэгдэх

болно. Дуул. 46:7.
12а ө.х. Иудей аюулгүй байдлын төлөө бусадтай нууцаар хуйвалдах явдал найдах ёсгүй.
13а ө.х. Бурханы өмнө гүн хүндэтгэлтэй хийгээд даруу байх.

мөн та нарын сүрдэх нь тэр байг.

14 Мөн тэрээр “дуган мэт байх болно; гэвч Израилын хоёр угсаанд хоёуланд нь тээглэх чулуу, мөн дургүйцлийн хад мэт байх болно, Иерусалимын оршин суугчдад занга мөн урхи байх болно.

15 Мөн тэдний дундаас олон нь “тээглэж бас унана, мөн хэмхлэгдэж, мөн урхидагдаж бас баривчлагдах болно.

16 Миний шавь нарын дунд гэрчлэлийг баринтагла, “хуулийг лацад.

17 Мөн Иаковын угсаанаас нүүрээ “буруулсан тэр Их Эзэнд хандан би хүлээх болно, мөн би түүнийг харуулах болно.

18 Болгоогтун, Сионы ууланд орших Түмний Их Эзэнээс Израилд “тэмдгүүд болон гайхамшгууд болгосон нь би, түүнчлэн Их Эзэн надад өгсөн хүүхдүүд буюу.

19 Мөн тэд чамд: Танил сүнс бүхий тэднээс хай, мөн “дуудагч мөн бувтналдан үглэх илбэчид болох тэднээс хай хэмээн хэлэх үед — амьд хүмүүс “үхэгсдээс сонсохын тулд Бурханаасаа хайх” ёсгүй гэж үү?

20 Хуулиас мөн гэрчлэлээс;

мөн хэрэв “тэд энэ үгийн дагуу ярихгүй аваас, энэ нь тэдэнд гэрэл үгүйн учир болой.

21 Мөн “тэд үүнийг туулахдаа хатуу бэрх бэрхшээл мөн өлсгөлөнг үзнэ; мөн улиран тохиох дор тэд өлсөх үедээ, тэд өөрсдийгөө уурлуулан зовоож, мөн дээш хандан хаанаа мөн Бурханаа зүхэх болно.

22 Мөн тэд газарт хандаж мөн бэрхшээл, мөн харанхуй, зовлонгийн мананг харах болно, тэгээд харанхуй тийш туугдах болно.

БҮЛЭГ 19

Исаиа Мессиагийнхаар ярина — Харанхуй дахь хүмүүс агуу гэрлийг харах болно — Бидний төлөө хүүхэд төрөх болно — Тэрээр Энх Амгалангийн Ханхүү байх болно мөн Давидын сэнтий дээр хаанчлах болно — Исаиа 9 дүгээр бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мээ 559–545 он.

Гэсэн хэдий ч, эхлээд тэрээр Зебулуны “нутаг мөн Нафталын нутгийг хөнгөн зүдрээж, мөн дараа нь Улаан тэнгисийн замд, Иордан голын цаана үндэстнүүдийг Галилд

14a Езек. 11:15–21.

б 1 Петр 2:4–8;

Иаков 4:14–15.

15a Мат. 21:42–44.

16a евр. Сургаалууд,

эсвэл номлол.

су Сайн Мэдээ.

17a Ис. 54:8.

18a ө.х. Исаиа болон

түүний хөвгүүдийн

нэр нь “Иехова авардаг”; “Тэрээр олз омогт яардаг”;

“Үлдэгсэд эргэж ирэх болно” гэсэн утгатай.

2 Ниф. 17:3; 18:3.

19a Лев. 20:6.

б ө.х. Илбэчид, мэрэг төлөгчид.

в эсвэл нэрийн өмнөөс.

г 1 Сам. 28:6–20.

20a ө.х. Сүнсний арга хэрэгсэл.

21a ө.х. Тэд анхааран сонсоогүйн улмаас Израил боолчлолд аваачигдах болно.

19 1a Мат. 4:12–16.

илүү эмгэнэлтэйгээр зовоосон үеийнх нь, уг манан түүний дургүйцэлд байсан лугаа адил тийм байхгүй болой.

2 “Харанхуйд алхдаг байсан хүмүүс агуу гэрлийг харсан аж; үхлийн сүүдэр татсан нутагт орших, тэдний дээр уг гэрэл туссан буюу.

3 Та үндэстнийг үржүүлж мөн баяслыг “нэмсэн—тэд таны өмнө ургацын баярын үеийнх мэт баясна, мөн эрчүүд тэд олзоо хуваахдаа баярлах лугаа адил болой.

4 Учир нь мөн түүний дарангуйллын буулгыг, мөн түүний мөрөн дээрх дарамтыг, түүний дарлагчийн савааг та хэмхэлсэн бөлгөө.

5 Тухайлбал дайчны тулаан бүр нь эх захгүй шуугиантай байж, мөн өмсгөл нь цусанд нэвчсэн байдаг; гэвч энэ нь түймэр мөн галын түлшний дунд байх болно.

6 Тухайлбал “хүүхэд бидний тул төрсөн, бидэнд хүү өгөгдсөн; мөн ^бзасаг захиргаа нь түүний мөрөн дээр байх болно; мөн түүний нэр нь Гайхамшигт, Зөвлөгч, ^вХүчит Бурхан, ^гҮүрдийн Эцэг, ^дЭнх Амгалангийн Ханхүү хэмээн дуурсах болно.

7 Давидын сэнтий дээр, мөн үүнийг журамлан мөн

үүнийг шударга байдал болон шударга ёсоор энэ цагаас эхлэн, бүр үүрд тогтоохын тулд түүний хаант улсын дээр “засаглалын мөн амар амгалангийн өсөлт ^бтөгсгөлгүй байна. Түмний Их Эзэний хичээл зүтгэл үүнийг гүйцэлдүүлэх болно.

8 Их Эзэн өөрийн үгийг Иаковт илгээж, мөн энэ нь “Израилын дээр тогтсон бөлгөө.

9 Мөн бүх хүмүүс мэдэх болно, бүр Ефраим болон Самарийн оршин суугчид бардам мөн бөх зүрхтэйгээр хэлдэг:

10 Тоосгонууд доош унасан, гэвч бид зассан чулуугаар барих болно; цагаан агч мод тайрагдан унасан, гэвч бид тэдгээрийг хуш модоор орлуулах болно хэмээсэн тэд буюу.

11 Тиймийн тул Их Эзэн “Резиний өрсөлдөгчдийг түүний эсрэг тавих болно, мөн түүний дайснуудыг нэгтгэн хамтатгах буюу;

12 Эхлээд Сирийнхэн тэгээд хойно нь Филистинийхэн; мөн тэд Израилыг ангайсан амаараа “үмхлэх болно. Энэ бүгд байсан ч түүний ^бхилэн зайлуулагдаагүй, харин ч гар нь далайсан хэвээр болой.

13 Учир нь хүмүүс өөрсдийг

2а “Бүрэнхий ба харанхуй” нь урвалт хийгээд боолчлол байв, “агуу гэрэл” бол Христ юм.

3а Иса. 9:3.

6а Иса. 7:14; Лук 2:11.

б Мат. 28:18.

в Тит. 2:13–14.

г Алма 11:38–39, 44.

д Иохан 14:27.

7а су Засгийн газар.

б Дан. 2:44.

8а ө.х. Шүлэг 8-21 дэх

бошиглолын

захиас нь Израил хэмээн нэрлэгддэг умардын арван овогт өгсөн сануулга байв.

11а Хаад. дэд 16:5–9.

12а Хаад. дэд 17:6, 18.

б Иса. 5:25; 10:4.

нь жанчих түүнд “хандахгүй, бас тэд Түмний Их Эзэнийг ч үл хайх бөлгөө.

14 Тиймийн тул Их Эзэн Израилаас нэгэн өдөр толгой мөн сүүлийг, мөчир болон салааг огтлон авах болно.

15 Ахмад нэгэн, тэр нь толгой; мөн худал хуурмагийг сургах бошиглогч, тэр нь сүүл буюу.

16 Өөрөөр хэлбэл энэ хүмүүсийн удирдагчид тэднийг гажуудуулна; мөн тэднээр удирдагдсан тэд устгагдах болно.

17 Тиймийн тул Их Эзэн тэдний залуу эрчүүдэд баясах нь үгүй, бас тэдний эцэггүй болон бэлэвсэнд “нигүүлсэл үгүй байх болно; учир нь тэдний хүн бүр нь хоёр нүүртэн мөн хилэнцийг үйлдэгч мөн ам болгон “мунхгийг ярих бөлгөө. Энэ бүгд болсон ч түүний хилэн зайлуулагдаагүй, харин ч түүний “гар далайсан хэвээр болой.

18 Өөрөөр хэлбэл ёсон бус нь гал лугаа адил шатна; энэ нь өргөс болон хатгууруудыг залгина, мөн ойн өтгөн шигүүд нь асах болно, мөн утаа дээш хөөрөх лугаа адил тэд замхрах болно.

19 Түмний Их Эзэний хилэнгээр уг нутаг харанхуйлагдан, мөн тэр хүмүүс галын түлш лугаа адил байх болно; “хэн ч

ахан дүүсээ хэлтрүүлэх нь үгүй болой.

20 Мөн тэрээр баруун гартаа шүүрэх боловч мөн өлсгөлөн байна; мөн тэрээр зүүн гардахиа “идэх болно мөн тэд ханах нь үгүй; тэд идэх болно, хүн бүр шууныхаа махыг буюу —

21 “Манассе “Ефраим; мөн Ефраим Манассе; тэд хамтдаа “Иудейн эсрэг байх болно. Энэ бүгд болсон ч түүний хилэн зайлуулагдаагүй, харин ч түүний гар далайсан хэвээр байгаа.

БҮЛЭГ 20

Ассирийн устгал нь Хоёр дахь Ирэлтийн үе дэх ёсон бусын устгалын адилтгал байна—Их Эзэн дахин ирсний дараа цөөн хүмүүс үлдэх болно—Иаковын үлдэгдэл тэр өдөр эргэж ирэх болно—Исаиа 10 дугаар бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мээ 559–545 он.

Зөв бус тогтоолыг тогтоох, мөн өөрсдийн зохиосон дарамтыг бичих тэдэнд халаг;

2 “Бэлэвсэн нь тэдний олз байх болно, мөн тэд эцэггүйг дээрэмдэж болохын тулд хэрэгцээтэйг “шударга ёсноос салгана, мөн миний хүмүүсийн ядуугаас эрхийг нь булаан авах тэдэнд буюу!

3 Мөн “айлчлалын уг өдөр, мөн холоос ирэх тэрхүү

13а Амос 4:6–12.

17а су Нигүүлсэнгүй, Нигүүлсэл.

б 2 Ниф. 9:28–29.

в Иаков 5:47; 6:4.

19а Мика 7:2–6.

20а Дэд хууль 28:53–57.

21а су Манассе.

б су Ефраим.

в су Иудей.

20 2а су Бэлэвсэн.

б эсвэл Шударга ёс.

3а ө.х. Шийтгэл.

хоосролын үед та нар юу хийх билээ? Хэнд та нар тусламж авахаар харайж очих билээ? Мөн та нар сүр хүчээ хаана орхих билээ?

4 Надгүйгээр тэд хоригдлуудын дор ч бөхөлзөх болно, мөн тэд алагдсаны дор унах болно. Энэ бүгд болсон ч түүний хилэн зайлуулагдаагүй, харин ч түүний гар далайсан хэвээр байгаа.

5 Ай Ассирийнхан, миний уур хилэнгийн саваа, мөн тэдний гарт байх таяг нь “тэдний зэвүүцэл болой.

6 Би түүнийг хоёр нүүртэн үндэстний “эсрэг илгээх болно, мөн би өөрийн хилэгнэсэн хүмүүст олзыг авч, мөн идшийг нь булаах, мөн тэднийг гудамжны балчиг шавхай лугаа адил доороо гишгэчих үүрэгийг түүнд өгөх болно.

7 Хэдий тийм ч, тэрээр ийн санасан нь үгүй, түүний зүрх сэтгэл ч бас тийн бодсон нь үгүй; гэвч тэр зүрх сэтгэлдээ цөөн биш үндэстнүүдийг устгаж мөн тусгаарлах буйза.

8 Өөрөөр хэлбэл тэрээр: Миний хунтайжууд бүхэлдээ хаадууд бус уу? хэмээв.

9 Кално нь Карчимиш шиг бус уу? Хамаф нь Арпад шиг бус уу? Самари нь Дамаск шиг бус уу?

10 “Миний гар хиймэл шүтээнүүдийн хаант улсуудыг

үндэслэсний адилаар, мөн тэдний зормол дүрсүүд Иерусалимын болон Самарийнхаас нэгэд илүү тэдгээрийг буюу;

11 Би Самарид мөн түүний хиймэл шүтээнүүдэд үйлдэний адилаар, Иерусалимд мөн түүний хиймэл шүтээнүүдэд тийн үйлдэх минь үгүй гэж үү?

12 Иймийн тул улиран тохиох дор Их Эзэн, Сионы Уулан дээр мөн Иерусалим дээр өөрийн бүхий л ажлыг гүйцэтгэсний дараа, би “Ассирийн хааны бөх зүрхтэйн үрийг мөн түүний дээгүүр харах сүр жавхланг нь шийтгэх болно хэмээв.

13 Өөрөөр хэлбэл “тэрээр хэлсэн нь: Өөрийн гарын хүчээр мөн өөрийн ухаанаар би эдгээр зүйлийг хийсэн бөлгөө; учир нь би бол хэрсүү хашир нэгэн; мөн би ард олны хил хязгааруудыг зөөсөн, мөн тэдний үнэтэйг дээрэмдэж, мөн би баатар хүн лугаа адил оршин суугчдыг нь дорд болгосон билээ;

14 Мөн миний мутар шувууны үүрэнд орсон мэт хүмүүсийн баялгийг олсон болой; мөн үлдсэн өндгүүдийг хураах нэгэн мэт би бүх дэлхийг хураав; мөн нэгээхэн нь ч далавчаа хөдөлгөж, эсвээс уруул нээж, эсвээс бувтнасан нь үгүй бөлгөө.

15 Түүгээр “цавчих хүний

5а Иса. 10:5.
6а ө.х. Израилын эсрэг.
10а ө.х. Ассирийн хааны гар (шүлэг 10-11).

12а Зеф. 2:13.
б ө.х. Сагсууран бардамнагчид.
13а ө.х. Ассирийн хаан (шүлэг 13-14).

15а ө.х. Бошиглогч хааныг багажтай харьцуулжээ.

эсрэг сүх өөрөөрөө бардамнах ⁶гэж үү? Үүнийг хөдөлгөгч түүний эсрэг хөрөө өөрөө ихэрхэх гэж үү? Торлог өөрөө үүнийг өргөсөн тэдний эсрэг сэгсэрдэг бил үү, эсвээс таяг модон биш юм шиг өөрийгөө өргөдөг бил үү!

16 Тиймийн тул Их Эзэн, Түмний Их Эзэн түүний өөгшүүлэгдсэн хүмүүсийн дунд, тарчгийг илгээнэ; мөн “түүний сүр хүчнийх нь доор тэрээр дүрэлзэх түймэр лугаа адил асаах болно.

17 Мөн Израилын гэрэл нь түймэр, мөн түүний Ариун Нэгэн бамбар байх болно, мөн түүний өргөс мөн түүний хатгууруудыг нэг өдөрт залгиж мөн шатах болно;

18 Мөн түүний шимт талбайн мөн түүний ойн сүр жавхланг цөлмөх болно, “сүнс болон биеийг аль алиныг нь буюу; мөн тэд тугч нь туйлдсан мэт байх болно.

19 Мөн түүний ойгоос “үлдсэн модод нь хүүхэд ч тэдгээрийг тоолж болохоор цөөн байх болно.

20 Мөнхүү улиран тохиох дор “тэр өдөр, ⁶Иаковын угсаанаас тэсэж давсан тэд болон Израилын үлдэгдэл нь,

өөрсдийг нь цохьсон түүнд дахин нэгээхэн ч “түшиглэхгүй, харин Израилын Ариун Нэгэнд, Их Эзэнд үнэнчээр түшиглэх болно.

21 “Үлдэгдэл нь, тийм ээ, бүр Иаковын үлдэгдэл нь, хүчит Бурханд эргэж ирэх болно.

22 Өөрөөр хэлбэл Израилчиний хүмүүс тэнгисийн элсний ширхэг мэт байх болно, тийм хэдий ч тэдний үлдэгдэл эргэж ирэх болно; уг тогтоогдсон “гарз нь зөв шударгыг ⁶халгилуулах болно.

23 Өөрөөр хэлбэл Түмний Их Эзэн Бурхан “гарзыг устгах болно, бүр бүх нутагт шийдэгдсэн буюу.

24 Тиймийн тул, Түмний Их Эзэн Бурхан тийн хэлнэ: Ай Сионд орших миний хүмүүс ээ, ассиричуудаас битгий ай; тэр та нарыг саваагаар цохих болно, мөн египетчүүдийн “нэгэн адилаар, та нарын эсрэг таягаа далайх болно.

25 Багахан хугацааны дараа, мөн зэвүүцэл зогсох болно, мөн миний уур хилэн тэдний устгалд ч болой.

26 Мөн Түмний Их Эзэн Оребын хадан дээрх “Мидианы аллагын дагуу түүний төлөө цээрлэлийг өдөөх болно;

15б Энэ шүлгэн дэх бүх зүйрлэл нь: Хүн Бурханы эсрэг цэцэглэн хөгжиж чадах уу? хэмээх нэг л асуултыг тавьсан байдаг.

16а ө.х. Ассирийн хаан (мөн шүлэг 17-19).

18а ө.х. Ассири ор мөргүй алга болно.

19а ө.х. Ассирийн их цэргийн үлдэгдэл.
20а ө.х. Хожмын өдрүүд.

б Амос 9:8–9.
в ө.х. Найдах, итгэх, хамаарах.

21а Иса. 11:11–12.

22а С ба Г 63:34.

су Дэлхий—
Дэлхийн төгсгөл.
б ө.х. Бүр шийтгэл

ирэх үед ч нигүүлсэл боломжтой бөлгөө.

23а ө.х. Тогтоогдсон устгалд хүргэх.

24а өх Египетчүүд эрт үед хийдэг байсны адилаар.

Ег. 1:13–14.

26а Эхл. 25:1–2;
Шүүгч. 7:25.

мөн түүний саваа тэнгисийн дээр байсны адил тэрээр үүнийг Египетийн маягаар далайх болно.

27 Мөнхүү улиран тохиох дор түүний “үүрэг чиний мөрөн дээрээс ховхорно, мөн түүний буулга чиний хүзүүнээс чинь мултарч уг буулга ⁶тослолтын учир устгагдах тэр өдөр болно.

28 “Тэрээр Аиафт ирж, тэр нь Мигроныг туулсан болой; Мичмашид тэр хөсгөө буулгасан болой.

29 Тэд хөтлийг даван одов; тэд Гебад өөрсдийн байрлалыг эзэгнэн авсан ажгуу; Рамаф эмээж буй; Саулын Гибеа зугтсан буюу.

30 Дугаа өргө, Ай Галлимьн охин; Лаишид сонсго, Ай хөөрхий Анафоф.

31 Мадмена зайлуулагдсан буюу; Гебимийн оршин суугчид зугтахаар өөрсдөө цуглацгааж байна.

32 Одоогийн адил тэр өдөр тэрээр Нобад үлдэх болой; тэрээр мутраа Сионы охины уул, Иерусалимын толгодын эсрэг сэгсрэх болно.

33 Болгоогтун, Их Эзэн, Түмний Их Эзэн гишүүг аймшигтайгаар тас цавчих болно; мөн өндрийн улмаас “дээр байгч нь доош тас чавчигдах

болно; мөн ихэмсгүүд даруусгагдах болно.

34 Мөн тэрээр ойн өтгөнийг төмрөөр тасчин буулгах болно, мөн Ливан хүчит нэгнээр унагаагдах болно.

БҮЛЭГ 21

Иессийн гол иш (Христ) зөв шударгад шүүх болно—Бурханы мэдлэг Мянганы үед энэ дэлхийг бүрхэх болно—Их Эзэн далбаа босгож, Израилыг цуглуулах болно—Исаиа 11 дүгээр бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мээ 559–545 он.

Мөн “Иессийн ⁶гол ишнээс ⁶салаа урга, мөн нэгэн мөчир түүний үндэснээс ургах болно.

2 Мөн Их Эзэний “Сүнс түүний дээр байх болно, мэргэн ухаан хийгээд ойлголтын суу билиг, хүч чадал ба зөвлөлийн суу билиг, мэдлэг хийгээд Их Эзэнээс айх айдсын тэрхүү суу билиг болой;

3 Мөн түүнийг Их Эзэнээс эмээхэд ойлголтыг нь сэргэг болгодог; мөн тэрээр өөрийн мэлмий үзэгдэх байдлаар аливааг үл “шүүнэ, бас өөрийн чихэнд сонсогдох авиагаар аливааг үл буруушаах буюу.

27a Иса. 14:25.

б су Тослогдсон Нэгэн.

28a ө.х. Иерусалим уруу чиглэсэн Ассирийн цэргийн давшилтын мөрөөр; тийнхүү (шүлэг 33-34)

тэдний эсрэг Их Эзэний ажиллагаа зүйрлэлээр дүрслэгджээ.

33a Хил. 4:12–13.

21 1a Иессе Давидын эцэг байв; ийнхүү Есүсийн төрсөн Давидын гэр бүл

хааны язгуур угсаатайг зааж ишлэл хийгджээ. Мика 5:2; Евр. 7:14. су Иессе.

б С ба Г 113:1–2.

в С ба Г 113:3–4.

2a Иса. 61:1–3.

3a Иохан 7:24.

4 Харин “зөв шударгаар тэрээр ядуусыг шүүх болно, мөн дэлхийн ^бномхон дөлгөөнчүүдийн төлөө шударга журмын дагуу “зэмлэл хүлээлгэх бөлгөө; мөн тэр үгэн саваагаараа энэ дэлхийг цохиж, мөн уруулаасаа гарах амьсгаагаар тэрээр ёс бусыг үйлдэгсдийг егүүтгэх болно.

5 Мөн зөв шударга байдал түүний хэвлийн тус бүслэгдсэн болно, мөн итгэл дүүрэн байдал түүний “ташаан тус бүслэгдэх болно.

6 Чоно хургатай түүнчлэн нэг дор орших болно, мөн ирвэс ишигтэй, мөн тугал болон залуу арслан мөн төл мал хамтдаа зэрэгцэн хэвтэх болно; мөн бяцхан хүүхэд тэднийг хариулах болно.

7 Мөн үнээ болон баавгай цуг идэшлэх болно; тэдний үр төл хамтдаа зэрэгцэн хэвтэх болно; мөн арслан шар лугаа адил дэрс идэх болно.

8 Мөн хөхүүл хүүхэд “загалмайт могойн нүхэнд наадах болно, мөн бойжсон хүүхэд гараа ^бхорт могойн үүрэнд хийх болно.

9 Тэд миний бүх ариун уу-

ланд “гэмтэхгүй бас устахгүй байх болно, учир нь Их Эзэний ^бмэдлэг дэлхийг тэнгис усаар бүрхсэн лугаа адил дүүргэх болно.

10 Мөн “тэр өдөр хүмүүсийн далбаа болж зогсох тэрхүү Иессийн ^бүндэс байх болно; “үүнийг ‘харийнхан эрэлхийлнэ; мөн түүний амар амгалан сүр жавхлантай байх болно.

11 Мөнхүү улиран тохиох дор тэр өдөр Их Эзэн Ассириас, мөн Египетээс, мөн Пафросоос, мөн Кушаас, мөн Эламаас, мөн Шинараас, мөн Хамафаас, мөн далайн арлуудаас үлдсэн өөрийн хүмүүсийн үлдэгдлийг буцаан авчрахын тулд “хоёр дахь удаагаа дахин мутраа хөдөлгөх болно.

12 Мөн тэрээр үндэстнүүдэд зориулан “далбаа босгож, Израилын ^бцөлөгдөгсөд чуулах болгож, мөн Иудейн тараагдагсдыг энэ дэлхийн дөрвөн зүгээс нэгтгэн “цуглуулах болно.

13 Еффраимын “атаа хорсол түүнчлэн оргүй арилах болно, мөн Иудейн сөргөлдөгчид зайлуулагдах болно; Еффраим

4a Дуул. 72:2–4;

Мозая 29:12.

б су Номхон дөлгөөн, Номхон дөлгөөн байдал.
в евр. Шийдэх.

5a эсвэл бэлхүүс.

8a Египетэд байдаг жижигхэн хорт могой.

б Өөр нэгэн хорт могой.

9a Иса. 2:4.

су Мянган жил.

б С ба Г 101:32–33;
130:9.

10a ө.х. Хожмын өдрүүд.

ИС—Т 1:40.

б Ром 15:12;
С ба Г 113:5–6.

в эсвэл түүнд,
түүний төлөө.

г С ба Г 45:9–10.

11a 2 Ниф. 6:14; 25:17;
29:1.

12a су Туг.

б 3 Ниф. 15:15; 16:1–4.

в Нех. 1:9;

1 Ниф. 22:10–12;

С ба Г 45:24–25.

су Израил—
Израилын
цугларалт.

13a Иер. 3:18.

⁶Иудейд үл “хорсож, мөн Иудей Ефраимыг үл өдөөх болно.

14 Харин тэд Филистиний мөрөн дээгүүр өрнө зүг “нисэх болно; тэд хамтран дорнын тэднийг тонох болно; тэд өөрсдийн гарыг Едом болон Моабын дээр далайх болно, мөн Аммоны хүүхдүүд тэднийг дуулгавартай дагах болно.

15 Мөн Их Эзэн Египетийн тэнгисийн хойгийг бүрмөсөн “устгах болно; мөн өөрийн хүчит салхиар мутраа голын дээгүүр сэгсрэх болно, мөн түүнийг долоон салаан дээр нь цохиж, мөн хүмүүсийг хуурай шаахайтай гатлан явах болгоно.

16 Мөн Ассираас үлдэх түүний хүмүүсийн үлдэгдэлд зориулагдсан, Египет нутгаас түүний гарч ирсэн тэр өдөр Израилд байсны адил “их зам байх болно.

БҮЛЭГ 22

Мянганы өдөр бүх хүмүүн Их Эзэнийг магтан дуулах болно— Тэрээр тэдний дунд орших болно— Исаиагийн 12 дугаар

бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мээ 559–545 он.

Мөн тэр өдөр чи хэлэх болно: Ай Их Эзэн, би таныг магтан дуулна; та надад уурласан гэлээ ч таны уур хилэн тайлагдан цэлмэх буюу, мөн та намайг тайтгаруулах буюу.

2 Болгоогтун, Бурхан бол миний аврал; би “найдах болно, мөн айх минь үгүй болой; учир нь Их Эзэн ⁶Иехова бол миний хүч мөн миний дуу; тэрээр түүнчлэн миний аврал болсон бөлгөө.

3 Тиймийн тул, та нар баяр хөөртэйгөөр авралын худгуудаас “ус татах болно.

4 Мөн тэр өдөр та нар хэлнэ: Их Эзэнийг “магтан дуулцгаа, түүний нэрийг дуудацгаа, түүний үйлсийг хүмүүсийн дунд тунхаглацгаа, түүний нэр өргөмжлөгдсөнийг дурдан хэлцгээ.

5 Их Эзэнд “дуулцгаа; учир нь тэрээр онц гайхамшигт зүйлийг хийсэн болой; энэ нь бүх дэлхийд мэдэгдсэн буюу.

6 “Хашгир мөн бархир, Сионы оршин суугч та; учир нь Израилын Ариун Нэгэн бол та нарын дунд агуу их билээ.

13б су Иудей.
в Иудей болон Ефраимын удирдсан овгууд түүхийн бүх үед дайснууд байв (Хаад. дээд 12:16-20 дахь үйл явдлын дараа). Хожмын өдрүүдэд энэхүү

дайсагнал арилах болно.)
су Атаархал.
14а ө.х. Филистиний нутаг байсан баруун бэлүүдийг довтолсон нь.
15а Зех. 10:11.
16а Иса. 35:8;
С ба Г 133:27.

22 2а Мозая 4:6;
Хил. 12:1.
б Ег. 15:2; Дуул. 83:18.
су Иехова.
3а су Амьдралын Ус.
4а су Талархалтай,
Талархах, Талархал өргөх.
5а С ба Г 136:28.
6а Иса. 54:1; Зеф. 3:14.

БҮЛЭГ 23

Вавилоны устгал бол Хоёр дахь Ирэлтийн үе дэх устгалын адилтгал болой—Тэр нь уур хилэн, өс хонзонгийн өдөр байх болно—Вавилон (дэлхий) үүрд унах болно—Исаиагийн 13 дугаар бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мээ 559–545 он.

Амозын хүү Исаиагийн харсан “Вавилоны ⁶тавилан оршвой.

2 Та нар “тугаа өндөр уулан дээр өргө, тэдэнд дуу хоолойгоо сонордуулцгаа, гараа ⁶даллацгаа, тэд язгууртны хаалгаар орж болохын тулд буюу.

3 “Ариусгагдсан тэдэнд би зарлигласан, би түүнчлэн өөрийн хүчтэнүүдийг дуудсан, тухайлбал миний уур эрхэм дээдэд минь баясах тэдний дээр бус болой.

4 Уулан дахь ардын чимээ агуу их хүмүүсийнх лугаа адил, үндэстнүүдийн “хаант улсуудын ⁶нэгдэн цугларсан нь шуугиант чимээ лугаа адил, Түмний Их Эзэн тулааны цэргүүдээ цуглуулах болно.

5 Тэд алсын улсаас, тэнгэрийн хаяанаас ирнэ, тийм ээ, Их Эзэн, мөн түүний зэвүүц-

лийн зэр зэвсэг, бүх нутгийг устгахаар буюу.

6 Та нар орь дуу тавьцгаа, учир нь Их Эзэний өдөр ойрхон байна; энэ нь Бүхнийг Чадагчаас устгал лугаа адил ирэх болно.

7 Тиймийн тул хүн бүрийн зүрх алдарч, гар болгон доройтох болно;

8 Мөн тэд айх болно; шимшрэл болон харамсал тэднийг эзэмдэн авах болно; тэд бие биесдээ гайхашран байх болно; тэдний царай улалзах дөл мэт байх болно.

9 Болгоогтун, Их Эзэний тэр өдөр хэрцгий уур мөн хилэн аль алиныг нь агуулсан харгислал нутгийг эзгүйрүүлэхээр ирэх болно; мөн тэрээр үүний нүгэлтнүүдийг тэндээс гарган “устгах болно.

10 Өөрөөр хэлбэл тэнгэрийн эрхсүүд мөн одны ордууд гэрлээ өгөхгүй байх болно; “нар мандах хэдий ч харанхуйлагдах болно, мөн сар гэрлээ туяаруулахгүй болно.

11 Мөн би дэлхийг нүгэл хилэнцийнх нь учир мөн ёсон бусыг үйлдэгчдийг алдсынх нь тул “шийтгэнэ; ⁶бардам нэгний ихэрхэг занг төгсгөл болгоно, мөн харгисын их занг дорд буулгах болно.

23 1a Иса. 13 ба 14-д бошиглогдсон ёс бус Вавилоны түүхэн устгал нь ёс бус бүхэл дэлхийн хэвийн бүрмөсөн устгалыг иш татан дурджээ.
су Бабел, Вавилон.

б ө.х. Муу хувь тавилангийн тухай захиас үг.
2a эсвэл Туг. су Туг.
б ө.х. Гараар даллах, дохио өгөх.
3a ө.х. Гэгээнтнүүд.
4a Зех. 14:2–3.

б Зех. 12:3.
9a су Дэлхий— Дэлхийн цэвэршилт.
10a су Дэлхий— Дэлхийн төгсгөл.
11a Малах. 4:1.
б С ба Г 64:24.

12 Би “хүмүүнийг шижир алтнаас илүү эрхэм; бүр хүмүүнийг Офирын алтан ембүүнээс илүү болгоно.

13 Тиймийн тул, Түмний Их Эзэний хилэнд мөн түүний догшин хилэнгийн тэр өдөр би тэнгэрийг сэгсэрч, дэлхий байрнаасаа “хөдлөх болно.

14 Мөн энэ нь “хөөгдсөн гөрөөс лугаа адил байх болно, мөн хариулах хүнгүй хонь мэт байх болно; мөн тэд хүн бүр төрөл төрөгсөддөө эргэж ирнэ, мөн аливаа хүмүүн зугтан нутгаа бараадах болно.

15 Бардам зант тэр болгон нэвт сүлбэгдэх болно; тийм ээ, мөн ёс бусыг үйлдэгсдэд нэгдсэн бүхэн илд мэсээр унагаагдах болно.

16 Тэдний хүүхдүүд түүнчлэн тэдний нүдний өмнө хэдэн хэсэг болон няцлагдах болно; тэдний гэр орон тоногдож мөн эхнэрүүд нь хүчирхийлэгдэх болно.

17 Болгоогтун, мөнгө болон алтыг эс үнэлнэ, бас үүнд үл баясах тэд болох медесчүүдийг тэдний эсрэг би өдөөн хатгах болно.

18 Тэдний нумнууд залуу эрчүүдийг ч түүнчлэн хэдэн хэсэг болгон тасдах болно; мөн тэд хэвлий дэх үрсийг эс өрөвдөх болно; тэдний нүд хүүхдүүдийг ч үл хэлтрүүлэх болно.

19 Мөн Вавилон, хаант

улсуудын сүр жавхлан, халдейчуудын гайхамшгийн “үзэсгэлэн, Бурхан ⁶Содом Гоморра хоёрыг устгасан тэр цагийн адил байх болно.

20 Энэ нь хэзээ ч “сууршигчидтай байхгүй, бас үеэс үед орших нь ч үгүй; бас Араб тэнд хэзээ ч майхан босгохгүй; бас хэзээ ч хоньчид тэнд сүргээ хариулахгүй.

21 Харин цөлийн “зэрлэг амьтад тэнд хэвтэх болно; мөн тэдний сууцнууд золгүй амьтдаар дүүрэн байх болно; мөн ууль тэнд орших болно, мөн ⁶чөтгөрүүд тэнд бүжиглэх болно.

22 Мөн арлын зэрлэг араатнууд тэдний эзгүй “сууцанд, мөн тэдний тааламжит ордонд ⁶луунууд архирах болно; мөн түүний цаг нь дөхөж, мөн түүний өдөр нь уртасгахгүй байх болно. Учир нь би түүнийг хурдан устгана; тийм ээ, өөрөөр хэлбэл би өөрийн хүмүүст нигүүлсэнгүй байна, гэвч ёсон бусыг үйлдэгчид мөхөх болно.

БҮЛЭГ 24

Израил цуглуулагдаж мөн мянганы амгаланг эдлэх болно— Люцифер эсэргүүцлийн улмаас тэнгэрээс зайлуулагдсан билээ— Израил Вавилоны (дэлхийн) дээр дуурсах болно— Исаиагийн

12а Иса. 4:1–4.

13а су Дэлхий—
Дэлхийн эцсийн
байдал.

14а эсвэл Агнасан буга.

19а ө.х. Хоосон зүйл.

б Эхл. 19:24–25;

Дэд хууль 29:23;
2 Ниф. 13:9.

20а Иер. 50:3, 39–40.

21а Иса. 34:14–15.

б Евр. Ухна буюу буг

чөтгөр.

22а Евр. Ордон, орд
харш.

б Евр. цөөвөр чоно
буюу зэрлэг ноход
бололтой.

14 дүгээр бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мээ 559–545 он.

Өөрөөр хэлбэл Их Эзэн Иаковт нигүүлсэнгүй хандана, мөн Израилыг “сонгосон хэвээр, мөн тэднийг өөрсдийнх нь нутагт тэднийг суурьшуулах болно; мөн ^бхарь этгээдүүд тэдэнтэй нэгтгэгдэх болно, мөн тэд Иаковын угсаанд хавсарга болно.

2 Мөн “хүмүүс тэднийг авч мөн өөрсдийнх нь газарт тэднийг авчрах болно; тийм ээ, дэлхийн хязгаарт алс холоос; мөн тэд амлалтын ^бнутгууддаа эргэж ирэх болно. Мөн Израилын угсаа тэднийг эзэмших болно, мөн Их Эзэний нутаг ^бзарц шивэгчингүүдийн төлөө байх болно; мөн тэд өөрсдийг нь боолчилж байсан тэднийг олзолж авах болно; мөн тэд өөрсдийн дарлагчдыг эзэгнэн захирах болно.

3 Мөнхүү улиран тохиох дор тэр өдөр Их Эзэн харамсал гашуудлаас тань, мөн айдсаас тань, мөн чамайг үйлчлэх болгогдсон тэр хүнд боолчлолоос тань “амрах чөлөөг чамд өгөх болно.

4 Мөнхүү улиран тохиох дор тэр өдөр чи “Вавилоны хааны эсрэг энэ зүйр үгийг авч, мөн хэлнэ: Дарлагч хэрхэн зогсох

болов, алтан хот хэрхэн оршихоо больсон билээ!

5 Их Эзэн ёсон бусыг үйлдэгчдийн савааг нь, захирагчдын очирт таягийг хугална.

6 Ард олныг уур хилэнгээр үргэлжлүүлэн цохсон тэрээр, үндэстнүүдийг уураараа захирсан тэрээр хавчигдан зовсон билээ, мөн нэгээхэн ч саад үл болно.

7 Бүхэл дэлхий амран, мөн намжина; тэд “дуулан аниргүйг эвдэх болно.

8 Тийм ээ, “шилмүүст модод танд баясна, мөн түүнчлэн Ливаны бүх хуш модод, хэлрүүн: Та дорд ^бунагаагдсанаас хойш нэгээхэн ^бмодчин бидний эсрэг ирээгүй болой.

9 Таныг ирэхэд тантай уулзахаар “там дороос таны тул хөдөлсөн юм; энэ нь таны төлөө ^бүхэгсдийг, дэлхийн удирдагч тэр бүгдийг бусниулна; энэ нь үндэстнүүдийн бүх хаадыг хаан сэнтийнээс босгосон бөлгөө.

10 Тэд бүгд ярьж мөн танд хэлнэ: Та бас бидний адил яданги болов уу? Та бидэнтэй ижил болов уу?

11 Таны сүр жавхлан доош булшинд авчрагдсан буюу; таны хийлийн дуу чимээ эс сонсогдох буюу; өтнүүд таны дор тархаж, мөн өтнүүд таныг бүрхэх ажгуу.

24 1а Зех. 1:17.

б Иса. 60:3–5, 10.

2а ө.х. Бусад

үндэстнүүд

Израилд туслах

болно.

б су Амлалтын

нутаг.

в Иса. 60:14.

3а Иош. 1:13;

С ба Г 84:24.

4а су Бабел, Вавилон.

7а Иса. 55:12.

8а евр. Агар мод.

б ө.х. Агар мод.

в евр. Мод огтлогч

бидний эсрэг

ирээгүй.

9а су Там.

б ө.х. Биенээс салсан

сүнснүүд.

12 “Чи яахан тэнгэрээс унах болов, Ай ^бЛюсифер, өглөөний хүү! Үндэстнүүдийг доройтуулсан чи газарт унагаагдах гэж үү!

13 Учир нь чи зүрхэндээ хэлнэ: Би тэнгэр өөд “дээшлэх болно, би өөрийн сэнтийг Бурханы оддын дээр өргөмжлөх болно; би ^бхойд зүгт орших, их хуралдайн уулсын дээр түүнчлэн суух болно;

14 Би үүлсийн өндрөөс дээгүүр дээшлэх болно; би Бүхний Дээдийн адил байх болно.

15 Гэвч чи доош тамд бүр “нүхний ёроолд авчрагдсан байна.

16 Чамайг харсан тэд чамайг “нарийвчлан ажиглах болно, мөн чамайг анхааран үзэж, мөн хэлнэ: энэ нь хаант улсуудыг чичиртэл дэлхийг доргиосон тэр хүн үү?

17 Мөн дэлхийг аглаг буйд мэт болгосон, мөн түүний хотуудыг устгасан, мөн хоригдлуудынхаа байрыг эс нээсэн нь энэ үү?

18 Үндэстнүүдийн бүх хаад, тийм ээ, тэд бүгд, тэдний нэг бүр нь “байрандаа алдар суутайгаар хэвтэх буюу.

19 Гэвч чи “жигшүүрт мөчрийн адил, булшнаасаа зайлуулагдсан, алагдсан тэдний үлдэгдэл, илдэнд нэвт сүлбүүлж ^бчулуун нүхэнд орхигдсон тэдний адил буюу; хөлийн дор дэвслэгдсэн хүүр лугаа лугаа адил бөлгөө.

20 Чи булшинд тэдэнтэй нэгдэхгүй байх болно, учир юун гэвэл чи өөрийн нутгийг устгаж мөн өөрийн хүмүүсийг хөнөөсөн билээ; “хилэнцийг үйлдэгчдийн ^бүр удам хэзээ ч алдарших нь үгүй.

21 Тэдний эцгүүдийн “алдсын учир түүний хүүхдүүдийн хөнөөлтөнд бэлтгэгцгээ, тэд өсөж өндийхгүй, бас нутаг өмчлөхгүй, дэлхийн гадаргууг хотуудаар дүүргэхгүй байхын тулд буюу.

22 Учир нь би тэдний эсрэг босох болно хэмээн, Түмний Их Эзэн өгүүлж, мөн Вавилоноос “нэрийг, мөн үлдэгдэл, мөн хүү, мөн ^бүеэлийг тусгаарлана хэмээн Их Эзэн хэлэх болно.

23 Би түүнчлэн үүнийг бухшувууны “эзэмшил мөн намаг шалбааг болгох болно, мөн би үүнийг устгалын ^бтуужуураар

12a С ба Г 76:26.

^б евр. Өглөөний од, үүрийн хүү. Ёс бус дэлхийн (Вавилон захирагч гэдэг нь бүх ёс бусын захирагч Люсиферийг хэлдэг.) су Чөтгөр; Люсифер.

13a Мосе 4:1–4.

^б ө.х. Вавилоны

итгэлийн дагуу оршдог бурхад. Дуул. 48:2.

15a 1 Ниф. 14:3.

16a евр. Тан уруу хяламхийн харах буюу танд найдах.

18a ө.х. Түүний гэр бүлийн онгон.

19a ө.х. Эсэргүүцэгдсэн мөчир, тайрагдах болон тоогдохгүй байх.

^б ө.х. Хамгийн доод тал, ёроол.

20a су Ёс бус, Ёс бус

явдал. ^б Дуул. 21:10–11; 37:28.

21a Ег. 20:5.

22a Сур. үгс 10:7.

^б Иов 18:19.

23a Иса. 34:11–15.

^б эсвэл Шүүр.

шүүрдэнэ хэмээн Түмний Их Эзэн хэлэх бөлгөө.

24 Түмний Их Эзэн тангараглаж, хэлрүүн: Гарцаагүй миний бодсончлон, тийн энэ нь улиран тохиох болно; мөн миний зорьсончлон, тийн байх болно—

25 Би “Ассири үндэстний түүнийг нутагтаа авчрах болно, мөн ^бөөрийн уулсын дээр түүнийг хөл дор дэвсэлнэ; чингээд түүний ^ббуулга тэднээс мултарч, мөн түүний ачаа тэдний мөрөн дээрээс зайлах болно.

26 Энэ нь бүх дэлхийд зорилго болон тавигдсан тэрхүү зорилго бөлгөө; мөн энэ нь “бүх үндэстний дээр сунгагдсан тэрхүү мутар бөлгөө.

27 Учир нь Түмний Их Эзэн зорилго тавьсан, мөн хэн цуцлах билээ? Мөн түүний мутар сунгагдсан, мөн хэн буцааж эргүүлэх билээ?

28 Хаан “Ахаз нас нөгчсөн тэр ^бжил сайхь тавилан байжээ.

29 Чамайг нам дарах түүний саваа хугарсны учир, бүх Палестин, чи бүү баярла; учир нь могойн үүрнээс наж могой гарч ирэх болно, мөн түүний үр нисдэг галт могой байх болно.

30 Мөн ядуугийн ууган нь

тэжээгдэн, мөн тарчиг нэг нь аюулгүй тайван хэвтэх болно; мөн би чиний үндсийг өлсгөлөнгөөр хөнөөнө, мөн тэр нь та нарын үлдэгдлийг хядах болно.

31 Гасал, Ай хаалга; уйл, Ай хот; чи, бүхэл Палестин чи айсандаа арчаагүй болсон; учир нь умардаас угаа суунаглаж, мөн түүний болзсон цагуудад хэн ч ганцаар байхгүй байна.

32 Үндэстнүүдийн элч нар тэгэхэд юу гэж хариулах билээ? Их Эзэн “Сионыг үндэслэх болно, мөн түүний хүмүүсийн ^бядуус үүнд ^битгэмжлэх болно.

БҮЛЭГ 25

Нифай энгийн тодорхой байдалд бахдав—Исаиагийн бошиглолууд эцсийн өдрүүдэд ойлгогдох болно—Иудейчүүд Вавилоноос эргэн ирнэ, Мессиаг цовдлон, мөн тараагдан мөн цээрлүүлэгдэх болно—Тэд Мессиад итгэх үедээ сэргээгдэх болно—Тэрээр Лихай Иерусалимыг орхисноос зургаан зуун жилийн дараа анх удаа ирэх болно—Нифайчууд Мосегийн хуулийг дагаж мөн Израилын Ариун Нэгэн болох Христэд

25a Уг сэдэв Ассирийн довтолгоо хийгээд Иудей дахь уналтыг өөрчилжээ мээ 701 он.
Хаад, дэд 19:32–37; Иса. 37:33–38.
б ө.х. Иудей болон Израилын уулс.
в Иса. 10:27.

26a ө.х. Яваандаа дэлхийн бүх үндэстнүүд энэ маягаар унагаагдах болно.
28a Хаад, дэд 16:20.
б ө.х. Ойролцоогоор мээ 720 оны орчим энэхүү ачаа буюу муу хувь

тавилангийн тухай захиас үг бошиглогдсон бол, харин Иудей хамгаалагдах байжээ.
32a су Сион.
б Зеф. 3:12.
в эсвэл Дотор нь хоргодох байр.

итгэв. Ойролцоогоор мэв 559–545 он.

Эдүгээ би, Нифай, өөрийн бичсэн, Исаиагийн амаар яригдсан үгсийн талаар зарим зүйлийг ярья. Учир нь болгоогтун, миний хүмүүсийн олонд нь ойлгоход “бэрх олон зүйлийг Исаиа ярьсан билээ; учир нь тэд иудейчүүдийн дундах бошиглолын арга ухааны талаар мэдэх нь үгүй.

2 Учир нь би, Нифай, тэдэнд иудейчүүдийн заншлын талаар олон зүйлийг заасан минь үгүй; учир нь тэдний “ажлууд харанхуйн ажлууд байв, мөн тэдний үйлүүд жигшүүрт үйлүүд байсан бөлгөө.

3 Иймийн тул, би өөрийн хүмүүст, миний бичих эдгээр зүйлийг цаашид хүлээн авах тэд бүгдэд бичье, Бурханы ярьсан үгийн дагуу, түүний шүүлтүүд, бүх үндэстнүүдийн дээр ирэхийг тэд мэдэж болохын тулд болой.

4 Иймийн тул, анхаарцгаа, Ай хүмүүс минь, Израилын угсааных болох та нар, мөн миний үгсийг чих тавин сонсогтоо; өөрөөр хэлбэл Исаиагийн үгс та нарт тодорхой бус учир, хэдий тийм боловч тэдгээр нь “бошиглолын ^бсуу билгээр дүүргэгдсэн тэд бүгдэд тодорхой юм. Харин би та нарт өөрт буй суу билгийн

дагуу бошиглолыг өгье; иймийн тул би Иерусалимаас эцэгтэйгээ гарч ирсэн тэр цагаас надад байсан “тодорхой байдлын дагуу бошиглох болно; учир нь болгоогтун, тэд сурч болохын тулд, өөрийн хүмүүст тодорхойгоор ярихад бодгаль минь баяснам.

5 Тийм ээ, мөн бодгаль минь “Исаиагийн үгсэд баяснам, учир нь би Иерусалимаас гарч ирсэн, мөн нүд минь ^биудейчүүдийн зүйлийг харсан, бас иудейчүүд бошиглогчдын зүйлийг ойлгодгийг би мэднэ, мөн тэд иудейчүүдийн зүйлүүдийн дагуу заалгаснаас бусдаар бол иудейчүүдэд яригдсан тэдгээр зүйлийг тэдний адил ойлгох хүмүүс өөр үгүй билээ.

6 Гэвч болгоогтун, би, Нифай, Иудейчүүдийн аргын дагуу хүүхдүүддээ заасан нь үгүй; гэвч болгоогтун, би өөрийн биеэр, Иерусалимд оршин байсан бөлгөө, иймийн тул би эргэн тойрны нутгийнх нь талаар мэднэ; мөн Исаиагийн ярьсан тэдгээр бүгдийн дагуу, хүүхдүүддээ иудейчүүдийн дунд “улиран тохиох Бурханы шүүлтүүдийн талаар би хүүхдүүддээ дурдсан, мөн би тэдгээрийг үл бичих болой.

7 Гэвч болгоогтун, би өөрийн, энгийн “тодорхой байдлын дагуу өөрийнхөө бошиглолыг

25 1a 2 Ниф. 25:5–6.
2a Хаад. дэд 17:13–20.
4a су Бошиглох,
Бошиглол.
б су Ариун Сүнс.

в 2 Ниф. 31:3; 33:5–6;
Иаков 4:13.
5a 1 Ниф. 19:23;
3 Ниф. 23:1.
б су Иудейчүүд.

6a 2 Ниф. 6:8;
Хил. 8:20–21.
7a 2 Ниф. 32:7;
Алма 13:23.

үргэлжлүүлье; ямар ч хүн алдах боломжгүйг мэдэх тэр байдлын тухай; гэсэн хэдий ч, Исаиагийн бошиглолууд биелэгдэх тэрхүү өдрүүдэд хүмүүс гарцаагүй мэднэ, тэдгээр нь улиран тохиох тэрхүү цагуудад болой.

8 Иймийн тул, тэдгээр нь хүмүүний үрсэд “чухал билээ, мөн тэдгээрийг тийм бус хэмээн бодох тэдэнд, ялангуяа тэдэнд би ярина, мөн үгсээ ^бөөрийнхөө хүмүүсээр хязгаарлая; өөрөөр хэлбэл тэдгээр нь ^вэцсийн өдрүүдэд тэдэнд агуу чухал зүйл байх болно гэдгийг би мэднэ; учир нь тэр өдөр тэд тэдгээрийг ойлгох болно; иймийн тул, тэдний тусын тулд би тэдгээрийг бичиглэсэн бөлгөө.

9 Мөн алдсын учир иудейчүүдийн дунд нэгэн үеийнхэн ^аустгагдсаны адил, тэрчлэн тэд үеэс үед алдсуудынхаа дагуу устгагдсаар байгаа буюу; мөн тэдэнд Их Эзэний бошиглогчдоор ^бугтан хэлэгдээгүй бол тэднээс нэгээхэн нь ч устгагдсан нь хэзээ ч үгүй билээ.

10 Иймийн тул, миний эцэг Иерусалимыг орхисон тэр даруй, тэдний дээр ирэх ёстой устгалын талаар тэдэнд хэлэгдсэн билээ; гэсэн хэдий ч,

тэд зүрх сэтгэлээ хатууруулсан; мөн миний бошиглолын дагуу Вавилонд боолчлолд ^ааваачигдсан тэднээс бусад нь ^бустгагдсан болой.

11 Мөн эдүгээ надад орших суу билгийн учир би үүнийг ярьж байна. Мөн тэд аваачигдсан гэлээ ч тэд дахин эргэж ирнэ, мөн Иерусалимын нутгийг эзэмших болно; иймийн тул, тэд өвлөсөн нутагтаа ^ссэргээгдэх болно.

12 Гэвч, болгоогтун, дайнууд мөн дайны цуурхлууд байх болно; мөн Эцэгийн ^аТөрсөн Ганцын, тийм ээ, бүр тэнгэр болон газрын Эцэг, өөрийгөө тэдэнд бие маханбодид үзүүлэх тэр өдөр ирэхэд, болгоогтун, тэд түүнийг эсэргүүцэх болно, учир юун гэвэл тэдний алдсуудын, мөн тэдний зүрх сэтгэлийн хатуугийн, мөн тэдний зөрүүдийн улмаас бөлгөө.

13 Болгоогтун, тэд түүнийг ^ацовдлох болно; мөн тэрээр хадан ^ббулшинд ^вгурав хоногийн турш хэвтүүлэгдсэний дараа тэр жигүүрэндээ анагаах чадлыг эзэмдэн нас барагсдаас ^гбосох болно; мөн түүний алдар сууд итгэх хэн боловч бүгд Бурханы хаант улсад аврагдах болно. Иймийн тул, түүний талаар

8а су Судрууд—
Судруудын үнэ
цэнэ.

б Инос 1:13–16;
Морм. 5:12–15;
С ба Г 3:16–20.

в су Эцсийн өдрүүд,
Хожмын өдрүүд.

9а Иер. 39:4–10;

Мат. 23:37–38.

б Амос 3:7;

1 Ниф. 1:13.

10а Хаад, дэд 24:14;

Иер. 52:3–16.

б 1 Ниф. 7:13;

2 Ниф. 6:8;

Омнаи 1:15;

Хил. 8:20–21.

11а Езра 1:1–4;

Иер. 24:5–7.

12а су Цорын Ганц.

13а Лук 23:33.

б Иохан 19:41–42;

1 Ниф. 19:10.

в Лук 24:6–7;

Мозая 3:10.

г су Амилуулалт.

бошиглоход бодгаль минь баясна, учир нь би түүний өдрийг ^ахарсан, мөн зүрх сэтгэл минь түүний ариун нэрийг алдаршуулна.

14 Мөн болгоогтун улиран тохиох дор “Мессиа нас барагсдаас босч, мөн өөрийгөө өөрийн хүмүүст, түүний нэрэнд итгэх тэр болгонд үзүүлсний дараа, болгоогтун Иерусалим дахин ^бустгагдах болно; өөрөөр хэлбэл Бурханы эсрэг мөн түүний сүмийн хүмүүсийн эсрэг тулалдах тэдэнд халаг.

15 Иймийн тул, “иудейчүүд бүх үндэстнүүдийн дунд ^бтараагдах болно; тийм ээ, мөн түүнчлэн ^вВавилон устгагдах болно; иймийн тул, иудейчүүд бусад үндэстнүүдээр тараагдах болно.

16 Мөн тэд тараагдаж, мөн Их Эзэн Бурхан тэднийг бусад үндэстнүүдээр олон үеийн турш цээрлүүлсний дараа, тийм ээ, бүр үеэс үед, тэд Бурханы Хүү, Христэд мөн бүх хүн төрөлхтний төлөөх хязгааргүй тэрхүү цагаатгалд “итгэхийг ятгуулах тэр үеийг хүртэл буюу— мөн тэд сэвгүй зүрх сэтгэл мөн цэвэр гартайгаар, Христэд итгэн мөн түүний нэрээр Эцэгийг бишрэн шүтэж, мөн

өөр ямар ч Мессиаг харуулдан хүлээхгүй тэрхүү өдөр ирэхэд, чингээд, тэр цагт, тэд эдгээр зүйлүүдэд итгэх нь зүйд нийцэх тэрхүү өдөр ирэх бөлгөө.

17 Мөн Их Эзэн төөрөлдсөн мөн унасан байдлаас нь өөрийн хүмүүсийг “сэргээхээр хоёр дахь удаагаа мутраа дахин хөдөлгөх болно. Иймийн тул, тэрээр хүмүүний үрсийн дунд ^бер бусын ажил мөн гайхамшигийг үйлдэхээ үргэлжлүүлэх болно.

18 Иймийн тул, тэрээр өөрийн “үгсийг тэдэнд авчрах болно, тэднийг эцсийн өдөр ^бшүүх тэр үгсийг, учир нь тэднээр эсэргүүцэгдсэн үнэн Мессиад тэднийг “итгүүлэх зорилгын учир тэдэнд тэдгээр нь өгөгдөх болно; мөн хүмүүсийг залилах тэр ‘хуурамч Мессиагаас өөр ямар нь ч ирэхгүй учир, өөр Мессиа ирэхийг тэд харуулдах хэрэггүй хэмээн тэдэнд итгүүлэхийн тулд бөлгөө; учир нь бошиглогчдоор яригдсан ганцхан Мессиа буй, мөн Мессиа нь иудейчүүдээр эсэргүүцэгдэх тэр бөлгөө.

19 Өөрөөр хэлбэл бошиглогчдын үгсийн дагуу, миний эцэг Иерусалимыг орхисон цагаас “зургаан зуун жилийн

13д 1 Ниф. 11:13–34.

14а су Мессиа.

б Лук 21:24;

ИС—А 1:1–18.

15а су Иудейчүүд.

б Нех. 1:8–9;

2 Ниф. 10:6.

в су Бабел, Вавилон.

16а 2 Ниф. 10:6–9; 30:7; Морм. 5:14.

17а 2 Ниф. 21:11–12; 29:1.

су Сайн мэдээний сэргээлт.

б Иса. 29:14;

2 Ниф. 27:26;

3 Ниф. 28:31–33.

18а 2 Ниф. 29:11–12;

33:11, 14–15.

б су Эцсийн Шүүлт.

в 2 Ниф. 26:12–13.

г су Христийн эсрэг.

19а 1 Ниф. 10:4;

3 Ниф. 1:1, 13.

тэртээ ^бМессиа ирнэ; мөн бошиглогчдын үгсийн мөн түүнчлэн Бурханы ^атэнгэр элчийн үгийн дагуу, түүний нэрийг Бурханы Хүү, Есүс Христ хэмээх болно.

20 Мөн эдүгээ, ах дүү нар минь, та нар алдаа гаргахын аргагүй тодорхойгоор би ярилаа. Мөн Израилыг Египетийн газар нутгаас ^агаргаж авчирсан, мөн үндэстнүүдийг тэд хорт могойнуудад хазуулсны нь дараа, хэрэв тэдний өмнө өргөсөн тэр ^бмогойг зовхи өргөн тэд харах аваас ^аанагаагдах хүчийг Мосед өгсөн, мөн түүнчлэн тэрээр ^ахадыг хагалан ус гаргах хүчийг түүнд өгсөн Их Эзэн Бурхан амьдын адил; тийм ээ, болгоогтун, би та нарт хэлнэ, Их Эзэн Бурхан амьдын адил, эдгээр зүйлүүд үнэний адил, түүгээр хүмүүн аврагдаж чадах миний ярьсан тэр Есүс Христийнхээс өөр ^внэр тэнгэрийн дор өгөгдөөгүй болой.

21 Иймийн тул, миний ^абичсэн эдгээр зүйлүүд хадгалагдан бас хамгаалагдана, мөн миний үр удамд, үеэс үед гардуулагдах болно хэмээн ий-

мийн улмаас Их Эзэн Бурхан надад амласан юм, түүний үр удам энэ дэлхий тогтнож байх цагт хэзээ ч үл ^бэрсдэнэ гэсэн уг амлалт Иосефт биелэгдэж болохын тулд буюу.

22 Иймийн тул, эдгээр зүйлүүд энэ дэлхий тогтнож байх цагт үеэс үед дамжин явах болно; мөн тэдгээр нь Бурханы таалал мөн хүслийн дагуу явах болно; мөн тэдгээрийг эзэмших үндэстнүүд, бичигдэх тэдгээр үгсийн дагуу ^ашүүгдэх болно.

23 Учир нь бид Христэд итгэж, мөн Бурханд нийцсэн байхыг хүүхдүүддээ мөн түүнчлэн ах дүүстээ ^аятгахын тулд бичихээр хичээнгүйлэн хөдөлмөрлөв; учир нь бид ^бач ивээлээр л бид аврагдана гэдгийг мэднэ, бидний ^ахийж чадах бүхний дараа буюу.

24 Мөн, бид Христэд итгэдэг хэдий ч, бид Мосегийн хуулийг ^адагадаг, мөн бат итгэлтэйгээр Христийг харуулдана, уг хууль гүйцэлдэх хүртэл бөлгөө.

25 Өөрөөр хэлбэл, ийм зорилгоор уг ^ахууль өгөгдсөн юм; иймийн тул уг хууль

19б су Есүс Христ—
Есүс Христийн төрөлт болон нас баралтын тухай бошиглол.
^в 2 Ниф. 10:3.
20а Ег. 3:7–10;
1 Ниф. 17:24, 31; 19:10.
^б Тоол. 21:8–9;
Алма 33:19;
Хил. 8:14–15.
^в Иохан 3:14;

1 Ниф. 17:41.
^с Ег. 17:6; Тоол. 20:11;
1 Ниф. 17:29; 20:21.
^д Хосеа 13:4;
Үйлс 4:10–12;
Мозая 5:8;
Мосе 6:52.
су Аврагч.
21а 2 Ниф. 27:6–14.
^б Амос 5:15;
2 Ниф. 3:16;
Алма 46:24–27.
22а 2 Ниф. 29:11;

33:10–15;
3 Ниф. 27:23–27.
23а су Хүүхэд, Хүүхдүүд.
^б Ром 3:23–24;
2 Ниф. 2:4–10;
Мозая 13:32;
Алма 42:12–16;
С ба Г 138:4.
су Ач ивээл.
^в Иаков 2:14–26.
су Ажлууд.
24а су Иаков 4:4–5.
25а су Мосегийн хууль.

бидэнд ^бүхмэл болсон, мөн итгэлийнхээ учир бид Христээр амьд болгогддог; гэсэн ч зарлигуудын учир бид уг хуулийг дагадаг бөлгөө.

26 Мөн бидний “хүүхдүүд нүглээс ^бангирхахын тулд ямар сурвалжийг хайж болохыг мэдэж болохын тулд бид Христийн тухай “ярьж, бид Христэд баясч, бид Христийн талаар номлож, бид Христийн тухай ‘бошиглож, мөн бид бошиглолуудынхаа дагуу бичдэг болой.

27 Иймийн тул, бидний хүүхдүүд уг хуулийн үхмэлийг мэдэж болно хэмээн бид уг хуулийн талаар ярьдаг; мөн тэд, уг хуулийн үхмэлийг мэдсэнээрээ, Христэд байх тэрхүү амьдралыг харуулдаг болох ажгуу, мөн уг хууль ямар зорилгын тулд өгөгдсөнийг мэдэх бөлгөө. Мөн Христээр уг хууль биелэгдсэний дараа, хууль цуцлагдах ёстой байхад тэд зүрх сэтгэлээ түүний эсрэг хатууруулах хэрэггүйг мэдэх болно.

28 Мөн эдүгээ болгоогтун, хүмүүс минь, та нар “гөжүүд хүмүүс; иймийн тул, та нар буруугаар ойлгож чадахааргүй тодорхойгоор би та нарт ярьсан. Мөн миний ярьсан үгс та нарын эсрэг ^бгэрчлэл болон зогсох болно; учир нь тэд ямар ч хүнд зөв замыг “заахад хангалттай; өөрөөр

хэлбэл зөв зам гэдэг нь Христэд итгэх мөн түүнийг үл үгүйсгэх юм; учир нь түүнийг үгүйсгэснээр та нар түүнчлэн бошиглогчид мөн хуулийг үгүйсгэх ажгуу.

29 Мөн эдүгээ болгоогтун, зөв зам нь Христэд итгэх, мөн түүнийг эс үгүйсгэх гэдгийг; мөн Христ бол Израилын Ариун Нэгэн гэдгийг би та нарт хэлнэ; иймийн тул та нар түүний өмнө доош бөхийж, мөн түүнийг өөрсдийн бүхий л “хүчин чадал, оюун, мөн чадлаараа, мөн өөрийн бүхэл бодгалиар бишрэн шүтэх ёстой; мөн хэрэв та нар үүнийг хийх аваас явч зайлуулагдах учиргүй.

30 Мөн, энэ нь зайлшгүйн хэрээр, та нар Мосед өгөгдсөн тэрхүү хуулийг биелэгдэх хүртэл Бурханы “ёслолууд хийгээд үйлүүдийг сахих ёстой.

БҮЛЭГ 26

Христ Нифайчуудад тохинуулах болно—Нифай өөрийн хүмүүсийн устгалыг угтан харав—Тэд газар шорооноос ярих болно—Харийнхан хуурамч сүмүүд мөн нууц холбоонууд байгуулах болно—Их Эзэн санваараар мэргэшихийг хүмүүнд хориглов. Ойролцоогоор мээ 559–545 он.

Мөн Христ нас барагсдаас

25б Ром 7:4–6.

26а су Хүүхэд,
Хүүхдүүд.

б су Нүглүүдийн
ангирхал.

в Иаков 4:12;

Жером 1:11;

Мозая 3:13.

г Лук 10:23–24.

28а Мозая 3:14.

б су Гэрчлэл.

в 2 Ниф. 33:10.

29а Дэд хууль 6:5;

Марк 12:29–31.

30а су Ёслолууд.

“боссоныхоо дараа тэрээр өөрийгөө та нарт ^бүзүүлэх болно, хүүхдүүд минь, мөн хайрт ах дүү нар минь; мөн түүний та нарт ярих үгс нь та нарын дагах тэрхүү ^ахууль байх болно.

2 Учир нь болгоогтун, олон үе улиран өнгөрч, мөн миний хүмүүсийн дунд их дайн мөн тэмцлүүд болохыг би болгоосон хэмээн би та нарт хэлнэ.

3 Мөн Мессиаг ирсний дараа миний хүмүүст түүний ^атөрөх, мөн түүнчлэн түүний үхлийн мөн амилалтын ^бтэмдгүүд өгөгдөх болно; мөн тэр өдөр ёс бусыг үйлдэгчдэд агуу болоод аймшигт байна, учир нь тэд эрсдэх болно; мөн тэд бошиглогчид, мөн гэгээнтнүүдийг зайлуулж мөн тэдний зүг чулуу нүүлгэж, мөн тэднийг хөнөөдгийн учир тэд мөхөх болно; иймийн тул гэгээнтнүүдийн ^ацусны хашгирах дуу тэдний эсрэг газар дэлхийгээс дээш Бурханд хүрэх болно.

4 Иймийн тул, бардам, мөн ёсон бусаар үйлдэгч тэд бүгдийг, Түмний Их Эзэний хэлсэнчлэн, тэднийг ^ашатаах тэр өдөр ирнэ, учир нь тэд талбайд хаягдсан сүрэл лугаа адил байх болно.

5 Мөн бошиглогчдыг, мөн гэгээнтнүүдийг хөнөөдөг тэд, газрын гүн нь тэднийг ^азалгих

болно хэмээн Түмний Их Эзэн хэлнэ; мөн ^буулс тэднийг дарна, мөн хар салхи тэднийг хийсгэн одно, мөн барилгууд тэдний дээр унаж мөн тэднийг жижиг хэсгүүд болгон няцалж мөн нунтаг болгон нүдэх болно.

6 Мөн аянга, мөн цахилгаан, мөн газар хөдлөлт, мөн бүх төрлийн устгалуудаар тэд дайлагдах болно, учир нь Их Эзэний хилэнгийн гал тэдний эсрэг дүрэлзэж байх болно, мөн тэд талбайд хаягдсан сүрэл мэт байх болно, мөн ирэх тэр өдөр тэднийг шатаана хэмээн Түмний Их Эзэн хэлсэн буюу.

7 Өөрийн хүмүүсийн хөнөөгдсөн алдагдлын учир зүрх сэтгэлийн минь тарчлал бас, Ай шаналал! Учир нь би, Нифай, үүнийг харсан, мөн энэ нь Их Эзэний дэргэд намайг бараг л сүйтгэх шахав; гэвч өөрийн Бурханд би: Таны замууд ^ашударга хэмээн залбирах ёстой.

8 Гэвч болгоогтун, бошиглогчдын үгсийг анхааран сонсох, мөн тэднийг үл устгах, харин бүх ^ахавчлагыг үл хайхран, өгөгдсөн тэмдгүүдийн учир гуйвшгүйгээр Христийг харуулдан хүлээх зөв шударгыг үйлдэгчид—болгоогтун, тэд бол ^бмөхөх нь үгүй тэд болой.

26 1а 3 Ниф. 11:1–12.

б 1 Ниф. 11:7; 12:6.

в 3 Ниф. 15:2–10.

3а су Есүс Христ—
Есүс Христийн
төрөлт болон нас
баралтын тухай

бошиглол.

б 1 Ниф. 12:4–6.

су Тэмдэг.

в Эхл. 4:10;

2 Ниф. 28:10;

Морм. 8:27.

4а 3 Ниф. 8:14–24; 9:3, 9.

5а 1 Ниф. 19:11;

3 Ниф. 10:14.

б 3 Ниф. 8:10; 9:5–8.

7а су Шударга ёс.

8а су Хавчих, Хавчлага.

б 3 Ниф. 10:12–13.

9 Харин Зөв Шударгын Хүү тэдэн “дээр хүрч ирэх болно; мөн тэрээр тэднийг ^банагаах болно, мөн тэд түүнтэй “гурван үе улиран өнгөртөл ^амар амгалан байх болно, мөн ^ддөрөв дэх үеийнхнээс олон нь зөв шударгаар улирч одох болно.

10 Мөн эдгээр зүйлүүд улирч өнгөрсний дараа миний хүмүүсийн дээр “устгал хурдан ирнэ; өөрөөр хэлбэл, зүрх сэтгэл минь шаналах хэдий ч, би үүнийг харсан; иймийн тул, энэ нь улиран тохиох болно гэдгийг би мэднэ; мөн тэд өөрсдийгөө хоосон зүйлээр арилжина; өөрөөр хэлбэл, өөрсдийн их зан мөн өөрсдийн мунхаглалын шагнал болгож тэд устгалыг хадаж авах болно; учир нь тэд чөтгөрт бууж өгөн мөн гэрлээс илүүгээр харанхуйн ажлуудыг сонгосон учир, тиймийн тул тэд доош ^бгамд очих ёстой ажгуу.

11 Учир нь Их Эзэний Сүнс хүмүүний төлөө үргэлж “тэмцэх нь үгүй. Мөн Сүнс хүмүүний төлөө тэмцэхээ болиход чингээд устгал хурдан ирнэ мөн энэ нь бодгалийг минь гонсойлгоно.

12 Мөн “иудейчүүд Есүс бол ^бтуйлын Христ гэдэгт “үнэмшүүлэгдэх талаар миний ярьсанчлан, Харийнхан түүнчлэн

Есүс бол Христ, Мөнхийн Бурхан гэдэгт үнэмшүүлэгдэх нь гарцаагүй буюу;

13 Мөн тэрчлэн “Ариун Сүнсний хүчээр тэрээр өөрийгөө түүнд итгэх тэд бүгдэд үзүүлнэ гэдэгт; тийм ээ, үндэстэн, ястан, хэлтэн, мөн хүмүүс болгонд, хүчит гайхамшгууд, тэмдгүүд мөн ер бусын явдлуудыг хүмүүний үрсийн дунд тэдний итгэлийн дагуу үйлдэнэ гэдэгт бөлгөө.

14 Гэвч болгоогтун, би та нарт “эцсийн өдрүүдийн талаар бошиглоё; Их Эзэн Бурхан эдгээр зүйлийг хүмүүний үрсэд ^бавчрах тэр өдрүүдийн талаар.

15 Миний үр удам болон ах нарын маань үр удам итгэлгүйдээ доройтож, мөн харийнханаар цохигдсоны дараа; тийм ээ Их Эзэн Бурхан тэдний эсрэг эргэн тойрон байрлаж, мөн тэдний эсрэг бэхлэлтээр бүслэн сууж, мөн тэдний эсрэг бэхлэлт босгосны дараа; мөн тэд доош дорд шороонд авчрагдсаны дараа, бүр тэднийг үгүй болтол, гэсэн ч зөв шударгыг үйлдэгчдийн үгс бичигдэх болно, мөн итгэлтний залбирлууд сонсогдох болно, мөн итгэлгүйдээ бууран доройтсон тэд мартагдах нь үгүй болой.

16 Учир нь устгагдах тэд

9а 3 Ниф. 11:8–15.
б 3 Ниф. 17:7–9.
в 1 Ниф. 12:11–12;
3 Ниф. 27:30–32.
г 4 Ниф. 1:1–4.
д Алма 45:10–12;
Хил. 13:9–10.

10а Алма 45:9–14;
Морм. 8:1–9.
б су Там.
11а Ифер 2:15.
12а 2 Ниф. 30:7;
Морм. 5:14.
су Иудейчүүд.

б Морм. 3:21.
в 2 Ниф. 25:18.
13а су Ариун Сүнс.
14а су Эцсийн өдрүүд,
Хожмын өдрүүд.
б су Сайн Мэдээний
сэргээлт.

газар шорооноос тэдэнд “ярих болно, мөн тэдний дуу хоолой газар дороос шивнэх болно, мөн тэдний дуу хоолой сүнс дуудагч лугаа адил байх болно; учир нь тэрээр тэдний талаар шивнэж болохын тулд Их Эзэн Бурхан түүнд хүчийг өгөх болно, бүр энэ нь газрын дороос байсан лугаа адил буюу; мөн тэдний яриа газар шорооноос шивнэх болно.

17 Өөрөөр хэлбэл Их Эзэн Бурхан ийн хэлдэг: Тэдний дунд хийгдэх зүйлийг тэд “бичих болно, мөн тэдгээр нь номонд бичигдэн мөн лацдагдах болно, мөн тэдгээрийг итгэлгүйдээ бууран доройтсон тэд эзэмшихгүй, тэд Бурханы зүйлийг устгахыг ^бэрэлхийлэхийн учир болой.

18 Иймийн тул, устгагдсан тэд хурднаар устгагдсаны учир юм; мөн аймшигт тэдний хүмүүс улирч гээгдэх “буданы хальс хог мэт байх болно — тийм ээ, Их Эзэн Бурхан ийн хэлнэ: Энэ нь агшин зуур, гэнэтхэн байх болно —

19 Мөнхүү улиран тохиох дор, тэдгээр итгэлгүйдээ бууран доройтоггод харийнханы гарт “цохигдох болно.

20 Мөн харийнхан өөрсдийнхөө нүдний “бардамналд хөөрсөн, мөн ^ббүдэрсэн, тэдний

“тээглэх чулууны ихийн учир, тиймээс тэд ‘олон сүм босгосон буюу; гэсэн хэдий ч тэд Бурханы хүч мөн гайхамшигийг дорд үзэн, мөн тэд хөрөнгө хурааж мөн ядуугийн нүүрийг ^аняцалж болохын тулд өөрсөддөө өөрсдийн мэргэн ухаан мөн өөрсдийн ‘суралцсанаа номлох болно.

21 Мөн атаа жөтөө, мөн хэрүүл маргаан, мөн “өшөө хорсол үүсгэх тэдгээр олон сүм босгогдсон билээ.

22 Мөн түүнчлэн “нууц холбоонууд, бүр хуучин цагт байсны адил, чөтгөрийн холбоонуудын дагуу байна, учир нь тэрээр эдгээр зүйлүүдийн үндэслэгч юм; тийм ээ, аллагын мөн харанхуйн ажлуудын үндэслэгч бөлгөө; тийм ээ, мөн тэрээр тэднийг бөх олсоор үүрд хүлэх хүртлээ, тэднийг маалинган оосроор хүзүүгээр нь оосорлон удирдах бөлгөө.

23 Учир нь болгоогтун, хайрт ах дүү нар минь, Их Эзэн Бурхан харанхуйд ажилладаггүйг би та нарт хэлье.

24 Тэрээр энэ дэлхийн төлөө бус аваас ямар ч зүйлийг эс хийх авай; учир нь тэрээр дэлхийг “хайрладаг, бүр тэрээр ^ббүх хүмүүнийг өөртөө ойртуулж болохын тулд тэр амиа өгсөн болой. Иймийн

16a Иса. 29:4;
Моро. 10:27;
Моисе 7:62.
су Мормоны Ном.
17a 2 Ниф. 29:12.
б Инос 1:14.
18a Морм. 5:16–18.
19a 3 Ниф. 16:8–9;

20:27–28.
20a су Бардамнал.
б 1 Ниф. 13:29, 34.
су Урвалт.
в Езек. 14:4.
г 1 Ниф. 14:10; 22:23;
Морм. 8:28.
д Иса. 3:15;

2 Ниф. 13:15.
е Морм. 9:7–8;
2 Ниф. 9:28.
21a су Атаархал.
22a су Нууц
хуйвалдаанууд.
24a Иохан 3:16.
б 3 Ниф. 27:14–15.

тул, тэрээр хэнд ч өөрийн авралыг бүү хүрт хэмээн үл зарлигладаг билээ.

25 Болгоогтун, тэрээр нэгээхэнд ч болов хэлрүүн: Надаас холд хэмээн айлдах уу? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй; харин тэр хэлдэг: Дэлхийн хязгаарууд та нар бүгд надад “ирэгтүн, мөнгөгүйгээр мөн төлбөргүйгээр, сүү болон бал ^бхудалдаж авцгаа.

26 Болгоогтун, тэд синагогоос гарч холдохыг, эсвээс шүтлэгийн өргөөнөөс гарахыг нэгээхэнд боловч тэрээр зарлигласан уу? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй.

27 Тэрээр өөрийн “авралаас тэд хүртэх ёсгүй хэмээн нэгээхэнд боловч зарлигласан уу? Болгоогтун би та нарт хэлнэ, Үгүй; харин тэрээр үүнийг бүх хүмүүний тулд үнэгүйгээр ^бөгсөн билээ; мөн тэд “наманчлахыг бүхий л хүмүүнд ятгах ёстойг тэрээр өөрийн хүмүүст зарлигласан билээ.

28 Болгоогтун, тэд өөрийнх нь сайн сайхнаас хүртэх ёсгүй хэмээн нэгээхэнд боловч Их Эзэн зарлигласан уу? Болгоогтун би та нарт хэлнэ, Үгүй; харин “бүх хүмүүн нэг нь нөгөөгийнхөө адил эрх бүхий бөгөөд нэг нь ч үл хориглогдсон болой.

29 Тэрээр “санваараар мэргэших нь байх ёсгүй хэмээн зарлигладаг; учир нь, болгоогтун, санваараар мэргэших нь тэд дэлхийгээс баялаг мөн ^балдрыг хурааж болохын тулд хүмүүний номнолыг номлож өөрсдийгөө хорвоогийн гэрэл болгодог; харин тэд Сионы аз жаргалын төлөө үл эрэлхийлдэг бөлгөө.

30 Болгоогтун, Их Эзэн энэ зүйлийг хориглосон билээ; иймийн тул, Их Эзэн Бурхан хүмүүнд “энэрэл, ^бхайр гэгдэх тэрхүү энэрэл байх ёстой хэмээх зарлиг өгсөн билээ. Мөн тэдэнд энэрэл байхгүй бол тэд юу ч биш болой. Иймийн тул, хэрэв тэдэнд энэрэл буй аваас тэд Сионд хөдөлмөрлөгч эрсдэхийг үл тэвчих буйза.

31 Гэвч Сионы хөдөлмөрлөгч “Сионы төлөө хөдөлмөрлөх болно; учир нь хэрэв тэд ^бмөнгөний төлөө хөдөлмөрлөх аваас тэд эрсдэх болно.

32 Мөн түүнчлэн, хүмүүн нь алах ёсгүй; тэд худал хэлэх ёсгүй; тэд хулгайлах ёсгүй; тэд Их Эзэн Бурханыхаа “нэрийг хий хоосон хэрэглэх ёсгүй; тэд атаархах ёсгүй; тэд хонзогнох ёсгүй; тэд өөр хоорондоо зөрчилдөх ёсгүй; тэд садар самууныг үйлдэх ёсгүй; мөн тэд эдгээр зүйлүүдийн алийг нь ч гэсэн хийх ёсгүй

25a Алма 5:33–35;
3 Ниф. 9:13–14.

б Иса. 55:1–2.

27a су Аврал.

б Ефес 2:8;

2 Ниф. 25:23.

в су Наманчлах,

Наманчлал.

28a Ром 2:11;

1 Ниф. 17:33–35.

29a су Санваараар
мэргэших.

б С ба Г 121:34–37.

30a Моро. 7:47–48.

су Энэрэл.

б су Хайр.

31a су Сион.

б Иаков 2:17–19;

С ба Г 11:7; 38:39.

32a су Бүдүүлэг үг
хэллэг.

хэмээн ⁶Их Эзэн Бурхан зарлигласан ажгуу; учир нь эдгээрийг хийх хэн ч гэсэн эрсдэх болно.

33 Учир нь эдгээр алдсуудын нэгээхэн нь ч Их Эзэнээс ирдэггүй; өөрөөр хэлбэл тэрээр хүмүүний үрсийн дунд сайн болох түүнийг л хийдэг; мөн тэрээр хүмүүний үрсэд тодорхойгоос бусдаар юуг ч үл хийнэ; мөн тэрээр тэднийг бүгд өөрт нь ирж мөн өөрийнх нь сайн сайхныг хүртэхийг урьдаг; мөн тэрээр хар ба цагаан, боол ба чөлөөт, эр болон эм, түүнд ирэх хэнээс боловч “үл татгалздаг; мөн тэрээр ⁶үнэн Бурханыг мэддэггүй хүмүүсийг ч санадаг; мөн Бурханд ⁶бүгд адил, Иудей болон Харь аль аль нь буюу.

БҮЛЭГ 27

Эцсийн өдрүүдэд харанхуй болон урвалт дэлхийг бүрхэх болно — Мормоны Ном ирэх болно — Гурван гэрч уг номыг гэрчлэх болно — Эрдэмт хүн тэрээр лацдагдсан номыг уншиж чадахгүй хэмээн хэлэх болно — Их Эзэн ер бусын ажил мөн гайхамшигийг үйлдэх болно — Исаиагийн 29 дүгээр бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мээ 559–545 он.

Гэвч, болгоогтун, “эцсийн

өдрүүдэд, өөрөөр хэлбэл харийнханы өдрүүдэд — тийм ээ, болгоогтун харийнханы бүх үндэстнүүд мөн түүнчлэн иудейчүүд, энэ газар дээр ирэх тэд мөн бусад газрууд дээр байх тэд аль аль нь, тийм ээ, бүр дэлхийн бүх нутгууд дээр, болгоогтун, тэд алдсуудад мөн бүх төрлийн жигшүүрт хэргүүдэд согтуурах бөлгөө —

2 Мөн тэр өдөр ирэх болоход тэд аянга мөн газар хөдлөлт, мөн агуу дуу чимээ, мөн шуурга, мөн хуй салхи, мөн залгигч галтай “түймрээр Түмний Их Эзэнээр зочлогдох болно.

3 Мөн Сионы эсрэг “тулалдах мөн түүнийг туйлдуулах бүх ⁶үндэстнүүд шөнийн үзэгдэл зүүд лугаа адил байх болно; тийм ээ, энэ нь тэдэнд, бүр зүүдлэх өлссөн хүний адил, мөн болгоогтун тэрээр идэх гэтэл тэрээр сэрнэ мөн түүний бодгаль хоосон байна, эсвээс зүүдлэх цангасан хүний адил, мөн болгоогтун тэрээр уух гэтэл тэрээр сэрнэ, мөн болгоогтун тэр харангадах болно, мөн бодгаль нь өлсгөлөн байх болно; тийм ээ, бүр Сион Уулын эсрэг тулалддаг бүх үндэстнүүдийн хүмүүс тийн байх болно.

4 Учир нь болгоогтун, алдсыг үйлдэгч та нар бүгд, зогсоцгоо мөн гайхацгаа, өөрөөр

32б су Бурханы зарлигууд.

33а Үйлс 10:9–35, 44–45.

б Алма 26:37.

в Ром 2:11;

1 Ниф. 17:35.

27 1а су Эцсийн өдрүүд, Хожмын өдрүүд.

2а Иса. 24:6; 66:15–16;

Иаков 6:3;

3 Ниф. 25:1.

3а 1 Ниф. 22:14.

б Иса. 29:7–8.

хэлбэл та нар хашгирцгаана, мөн уйлах болно; тийм ээ, та нар согтох болно, харин дарсанд бус, та нар хөлчүүрхэх болно, харин хүчит ундаанд бус.

5 Учир нь болгоогтун, Их Эзэн та нарын дээр гүн нойрны нөлөөг цутган юүлэх бөлгөө. Учир нь болгоогтун, та нар нүдээ аньж, мөн бошиглогчдыг эсэргүүцсэн; мөн та нарын алдсын учир та нарын захирагчид мөн үзмэрчдийг тэрээр халхалсан болой.

6 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Бурхан “номны үгсийг ^бта нарт авчрах болно, мөн тэдгээр нь үүрд нойрсон тэдний үгс байх болно.

7 Мөн болгоогтун ном ^алацдагдах болно; мөн уг номонд Бурханаас өгсөн нэгэн ^билчлэлт байх болно, энэ дэлхийн эхлэлээс түүний ^втөгсгөлийг хүртэлх буюу.

8 Иймийн тул, ^алацдагдсан зүйлүүдийн учир, лацдагдсан зүйлүүд нь хүмүүсийн ёсон бус мөн жигшүүрт хэргийн өдөрт ^бхүргэгдэхгүй бөлгөө. Иймийн тул уг ном тэднээс халхлагдах болно.

9 Гэвч уг ном нэгэн “хүнд хүргэгдэнэ, мөн тэрээр газар шороонд нойрссон тэдний үгс болох тэр номын үгсийг хүргэж, мөн тэрээр эдгээр

үгсийг ^бөөр нэгэнд хүргэх болно;

10 Гэвч номыг хүргэхгүй бас лацдагдсан үгсийг тэрээр хүргэх нь үгүй. Учир нь уг ном Бурханы хүчээр лацдагдах болно, мөн лацдагдсан илчлэлт нь тэдгээр нь ирж болно гэсэн Их Эзэний өөрийнх нь тогтоосон цагийг хүртэл уг номонд хадгалагдах болно; учир нь болгоогтун, тэдгээр нь дэлхийн сууринаас түүний төгсгөл хүртэл бүх зүйлийг илчлэх болно.

11 Мөн тэр номын лацдагдсан үгс дээвэр дээрээс уншигдах тэрхүү өдөр ирнэ; мөн тэдгээр нь Христийн хүчээр уншигдах болно; мөн хүмүүний үрсийн дунд байсан тэдгээр, мөн бүр дэлхийн төгсгөлийг хүртэл байх тэдгээр бүх зүйл хүмүүний үрсэд ^аилчлэгдэх болно.

12 Иймийн тул, миний ярьсан тэр хүнд уг ном хүргэгдэх тэр өдөр, уг ном дэлхийн нүднээс далдлагдах болно, тиймээс ^агурван ^бгэрч үүнийг Бурханы хүчээр болгоохоос бусдаар нэг ч нүд үүнийг үзэх нь үгүй, уг ном хүргэгдэх түүнээс гадна буюу; мөн тэд уг номын мөн түүнд буй зүйлүүдийн үнэнийг гэрчлэх болно.

13 Мөн Бурханы ^атааллын дагуу байх түүний үгийг

6а 2 Ниф. 26:16–17;
29:12.

сү Мормоны Ном.

б Жером 1:2;

Морм. 5:12–13.

7а Иса. 29:11–12;

Ифер 3:25–27; 4:4–7.

б Мозая 8:19.

в Ифер 13:1–12.

8а Ифер 5:1.

б 3 Ниф. 26:9–12;

Ифер 4:5–6.

9а С ба Г 17:5–6.

б ИС—Т 1:64–65.

11а Лук 12:3; Морм. 5:8;

С ба Г 121:26–31.

12а 2 Ниф. 11:3;

Ифер 5:2–4;

С ба Г 5:11, 15; 17:1.

б Дэд хууль 19:15.

13а 2 Ниф. 3:19–20;

33:13–15;

Моро. 10:27.

хүмүүний үрсэд гэрчлэн өгүүлэх тэр цөөн хэдээс өөр үүнийг харах бусад нь үгүй; өөрөөр хэлбэл итгэлтний үгс нас барагсдаас мэт ярихыг Их Эзэн Бурхан хэлсэн болой.

14 Иймийн тул, Их Эзэн Бурхан уг номын үгсийг урагш авчрахыг зорих болно; мөн тэрээр өөрийн үгийг байвал зохино хэмээсэн тооны гэрчүүдийн амаар нотлуулах болно; мөн Бурханы үгийг “эсэргүүцэх түүнд халаг болох буюу.

15 Гэвч болгоогтун, улиран тохиох дор Их Эзэн Бурхан уг номыг өгөөд, түүнд хэлнэ: Лацдагдаагүй эдгээр үгсийг авч мөн өөр нэгэнд хүргэ, тэрээр тэдгээрийг эрдэмт нэгэнд үзүүлж болохын тулд, хэлэх нь: Үүнийг “унш, би танаас гуйя. Мөн эрдэмт тэр хэлнэ: Номыг нааш авчир, мөн тэдгээрийг би уншъя гэнэ.

16 Мөн эдүгээ, дэлхийн алдар мөн “эд хөрөнгө олохын тулд тэд үүнийг хэлэх болно, мөн Бурханы алдар суугийн төлөө бус болой.

17 Мөн уг хүн хэлнэ: Би номыг авчирч чадахгүй, учир нь энэ нь лацдагдсан байна.

18 Тэгэхэд эрдэмт нь хэлнэ: Би үүнийг уншиж чадахгүй.

19 Иймийн тул улиран тохиох дор, Их Эзэн Бурхан номыг мөн түүний үгсийг суралцаагүй түүнд дахин хүргэх болно; мөн тэр сурал-

цаагүй хүн хэлнэ: Бибээр суралцаагүй.

20 Тэгэхэд Их Эзэн Бурхан түүнд хэлнэ: Эрдэмт нь тэдгээрийг үл уншина, учир нь тэд тэдгээрийг эсэргүүцэв, мөн би өөрийн ажлыг хийж чадна; иймийн тул чамд миний өгөх үгсийг чи унших болно.

21 Лацдагдсан тэдгээр зүйлүүдэд “бүү хүр, учир нь би тэдгээрийг өөрийн зохих цагт гарган авчрах болно; өөрөөр хэлбэл өөрийн ажлыг би өөрөө хийж чадна гэдгийг би хүмүүний үрсэд үзүүлэх болно.

22 Иймийн тул, миний чамд зарлигласан тэдгээр үгсийг чи уншиж, мөн миний чамд амласан тэдгээр “гэрчүүдийг авсны дараа, чи номыг дахин лацдана, мөн миний төлөө үүнийг далдлах болно, чиний уншаагүй үгсийг би өөрийн мэргэн ухаанд бүх зүйлийг хүмүүний үрсэд илчилбэл зохихыг хүртэл хадгалж болохын тулд буюу.

23 Учир нь болгоогтун, би бол Бурхан, мөн би бол “гайхамшгуудын Бурхан; мөн энэ дэлхийд би өчигдөр, өнөөдөр, мөн үүрд “адил гэдгийг би үзүүлэх болно; мөн тэдний итгэлийн дагуу байхаас “бусдаар би хүмүүний үрсийн дунд ажиллах нь үгүй.

24 Мөн түүнчлэн улиран тохиох дор Их Эзэн түүнд

14а 2 Ниф. 28:29–30;

Ифер 4:8.

15а Иса. 29:11–12;

ИС—Т 1:65.

16а су Санваараар

мэргэших.

21а Ифер 5:1.

22а су Мормоны

Номны гэрчүүд.

23а су Гайхамшиг.

б Евр. 13:8.

в Евр. 11;

Ифер 12:7–22.

хүргэгдэх үгсийг унших түүнд ийн хэлэх болно:

25 “Энэ хүмүүс өөрсдийн амаар надад ойр болж, мөн тэдний уруул намайг ^балдаршуулна, харин зүрх сэтгэлээ надаас холдуулсан, мөн тэдний надад хандах айдас нь хүмүүний “заавраар сургагдсаны хэрээр—

26 Тиймийн тул, би энэ хүмүүсийн дунд “гайхамшигт ажлыг, тийм ээ, ^бер бусын үйлийг мөн гайхамшигийг үйлдэхээр зорих болно, өөрөөр хэлбэл тэдний мэргэн ухаантны мөн суралцсаны ухаан нь мөхөх болно, мөн тэдний хэрсүү ухаантны ойлголт далдлагдах болно.

27 Мөн өөрсдийн бодол зорилгыг Их Эзэнээс нуухаар гүнийг эрэлхийлэх тэдэнд “халаг! Мөн тэдний ажлууд харанхуйд байдаг; мөн тэд хэлдэг: Хэн биднийг үзэж, мөн хэн биднийг мэдэх билээ? Мөн тэд түүнчлэн хэлдэг: Гарцаагүй зүйлийг урвуулан эргүүлэх тань ^бваарчны шавар адил үнэлэгдэх болно. Гэвч болгоогтун, би тэдэнд үзүүлэх болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг, би тэдний бүх ажлыг мэднэ гэдгийг болой. Өөрөөр хэлбэл ажил нь үүнийг хийсэн эзнээ, тэрээр намайг хийгээгүй гэх хэрэг үү? Эсвэл аливаа үйлүүд

нь үйлдэгсдээ тэрээр ойлголтгүй гэх хэрэг үү?

28 Түмний Их Эзэн хэлэв: Гэвч болгоогтун, Ливан шимт талбай болон хувиргагдах хүртэл бяцхан хугацаа үлдээд буйг би хүмүүний үрсэд үзүүлэх болно; мөн шимт талбай ой мэт үнэлэгдэх болно.

29 “Мөн тэр өдөр дүлий нь уг номын үгсийг сонсон, мөн хараагүй нэг нь тодорхой бус байдлаас ч, мөн харанхуйгаас ч харах болно.

30 Мөн түүнчлэн “номхон дөлгөөнчүүд нэмэгдэх болно, мөн тэдний ^ббаясал Их Эзэнд байх болно, мөн хүмүүний дунд ядуу нь Израилын Ариун Нэгэнд баясах болно.

31 Учир нь Их Эзэн амьд нь эргэлзээгүйн адил тэд “аймшигт нэгэн хий хоосонд авчрагдахыг харах болно, мөн элэглэгч нь үрэгдэхийг, мөн алдсыг хайгч тэд бүгд тусгаарлагдахыг болой;

32 Мөн хүнийг үгээр нь “хэрэгтэн болгогч, мөн ^болны нүдэн дээр зэмлэх түүнд урхи тавих тэднийг, мөн шударгыг хий хоосны тулд “буцаах тэднийг болой.

33 Тиймийн тул Иаковын угсааныхны талаар, Абрахамыг гэтэлгэсэн Их Эзэн тийн хэлэв: Иаков эдүгээ ичих нь үгүй, басхүү түүний нүүр цонхийсон байх нь ч үгүй болой.

25a Иса. 29:13.

б Мат. 15:8.

в 2 Ниф. 28:31.

26a 1 Ниф. 22:8;

2 Ниф. 29:1–2.

су Сайн Мэдээний сэргээлт.

б Иса. 29:14;

2 Ниф. 25:17.

27a Иса. 29:15.

б Иер. 18:6.

29a Иса. 29:18.

30a су Номхон

дөлгөөн, Номхон

дөлгөөн байдал.

б С ба Г 101:36.

31a Иса. 29:20.

32a Лук 11:54.

б Амос 5:10.

в 2 Ниф. 28:16.

34 Гэвч тэрээр өөрсдийнх нь хүүхдүүд болох миний мутраар хийгдсэн ажлыг өөрсдийнхөө дунд байхыг “хараад, тэд миний нэрийг бишрэн, мөн Иаковын Ариун Нэгэнийг биширч, мөн Израилын Бурханаас эмээх болно.

35 Түүнчлэн сүнслэг байдалдаа “алдаа хийгсэд, тэд ойлголтонд ирэх болно, мөн бувтнасан тэд сургаалыг ⁶суралцах болно.

БҮЛЭГ 28

Эцсийн өдрүүдэд олон хуурамч сүм босгогдох болно—Тэд хуурамч, хоосон, мөн мунхаг сургаалууд заах болно—Хуурамч багш нарын учир урвалт элбэг байх болно—Чөтгөр хүмүүний зүрх сэтгэлд улангасах болно—Тэр бүх төрлийн буруу сургаалууд заах болно. Ойролцоогоор мээ 559–545 он.

Мөн эдүгээ, болгоогтун, ах дүү нар минь, Сүнс намайг албадсаны дагуу би та нарт ярьсан; иймийн тул, тэдгээр нь гарцаагүй улиран тохиох ёстойг би мэднэ.

2 Мөн уг “номноос бичигдэх зүйлүүд нь хүмүүний үрсэд мөн ялангуяа Израилын угсааны үлдэгдэл болох бидний үр удамд маш ⁶чухал байх болно.

3 Өөрөөр хэлбэл “сүмүүд Их Эзэний төлөө биш босгогдох тэр өдөр улиран тохионо, нэг нь нөгөөдөө: Болгоогтун, би, би бол Их Эзэнийх; мөн бусад нь хэлнэ; би, би бол Их Эзэнийх; мөн Их Эзэний төлөө бус сүм босгосон хүн бүртийн хэлэх болно—

4 Мөн тэд өөр хоорондоо зөрчилдөх болно; мөн тэдний санваартнууд нэг нэгэнтэйгээ тэмцэх болно, мөн тэд өөрсдийн “суралцсанаас заах болно, мөн зааврыг өгөх Ариун Сүнсийг үгүйсгэх болно.

5 Мөн тэд Израилын Ариун Нэгэн, Бурханы “хүчийг ⁶үгүйсгэх болно; мөн тэд хүмүүст хэлнэ: Биднийг анхааран сонсоцгоо, мөн та нар бидний зааврыг сонсоцгоо; учир нь болгоогтун өнөөдөр “Бурхан гэж үгүй, учир нь Их Эзэн мөн Гэтэлгэгч өөрийн ажлыг хийсэн билээ, мөн тэрээр хүмүүнд өөрийн хүчийг өгсөн билээ;

6 Болгоогтун, та нар миний зааврыг анхааран сонс; хэрэв тэд Их Эзэний мутраар гайхамшиг хийгдсэн хэмээвэл үүнд бүү итгэ; учир нь энэ өдөр тэр бол “гайхамшгуудын Бурхан биш; тэрээр өөрийн ажлыг хийчихсэн шүү дээ.

7 Тийм ээ, мөн ийнхүү хэлэх нь олон байх болно: “Ид, уу, мөн баяс, учир нь маргааш

34а Иса. 29:23–24.

35а 2 Ниф. 28:14;

С ба Г 33:4.

б Дан. 12:4.

28 2а су Мормоны Ном.

б 1 Ниф. 13:34–42;

22:9; 3 Ниф. 21:6.

3а 1 Кор. 1:10–13;

1 Ниф. 22:23;

4 Ниф. 1:25–29;

Морм. 8:28, 32–38.

4а 2 Ниф. 9:28.

5а 2 Тим. 3:5.

б 2 Ниф. 26:20.

в Алма 30:28.

6а Морм. 8:26; 9:15–26.

7а 1 Кор. 15:32;

Алма 30:17–18.

бид үхнэ; мөн энэ нь бидэнд сайн байх болно.

8 Мөн үүнчлэн ийнхүү хэлэх нь олон байна: Ид, уу, мөн баяс; гэсэн хэдий ч, Бурханаас эмээ — тэр бяцхан нүгэл үйлдсэнийг “зөвтгөнө; тийм ээ, бяцхан ^бхудал хэл, өөр нэгийг түүний үгсийнх нь учир далимдуул, хөршүүддээ ^бнүх малт; үүнд хор хөнөөл гэж үгүй; мөн эдгээр бүх зүйлийг хий, учир нь маргааш бид үхнэ; мөн хэрэв түүнчлэн байснаар бид буруутай аваас, Бурхан биднийг хэдхэн удаа ташуурдах болно, мөн эцэст нь бид Бурханы хаант улсад аврагдах болно.

9 Тийм ээ, мөн тэд ийм маягаар, хуурамч мөн хоосон мөн “мунхаг ^бсургаалуудыг заах бөлгөө, мөн зүрх сэтгэлдээ ихэмсэглэдэг, мөн бодол санаагаа Их Эзэнээс нуухаар гүнзгийг эрэлхийлэх тэд олон байх болно; мөн тэдний ажлууд харанхуйд байх болно.

10 Мөн гэгээнтнүүдийн “цус газраас тэдний эсрэг хашгирах болно.

11 Тийм ээ, тэд бүгд “замаас гарч оджээ; тэд ^бзавхарчээ.

12 “Бардамналын учир, мөн хуурамч багш нарын, мөн хуурамч сургаалын учир, тэдний сүмүүд ялзарчээ, мөн

тэдний сүмүүд ихэмсэглэдэг; бардамналын учир тэд ихэмсэг болжээ.

13 Тэд “ядууг ^бдээрэмдэн, өөрсдийн сайхан дуганы учир буюу; тэд ядууг дээрэмддэг, өөрсдийн сайхан хувцасны улмаас буюу; мөн тэд номхон дөлгөөнчүүдийг мөн ядуу зүрхтэйг хавчдаг, тэд “бардамналдаа ихэмсэглэсний учир буюу.

14 Тэд “хүзүүгээ гаанайлган мөн дээгүүр хардаг; тийм ээ, мөн бардамналын, мөн ёсон бус, мөн жигшүүрт хэрэг, мөн садар самууны учир, Христийн даруу дагалдагчид болох цөөн хэдээс бусад нь тэд бүгд ^бтөөрөлдөн одсон бөлгөө; гэсэн хэдий ч тэд удирдагдана олон тохиолдолд тэд хүмүүний дүрмүүдээр сургагдсан учир тэд алдаа гаргадаг.

15 Ай сэтгэл дэх “бардамналдаа ихэмсэглэсэн ^бмэргэн ухаантнууд, мөн эрдэмтэд, мөн баячууд, мөн хуурамч сургаалуудыг номлох тэд бүгд, мөн садар самууныг үйлдэх мөн Их Эзэний зөв замыг гажуудуулах тэд бүгд, тэдэнд “халаг, халаг, халаг болог, учир нь тэд тамд доош түлхэгдэх болно хэмээн Их Эзэн Бүхнийг Чадагч Бурхан хэлдэг!

8а Морм. 8:31.

б С ба Г 10:25;

Моисе 4:4.

сү Худал хэлэх.

в Сур. үгс 26:27;

1 Ниф. 14:3.

9а Езек. 13:3;

Хил. 13:29.

б Мат. 15:9.

10а Илч. 6:9–11;

2 Ниф. 26:3;

Морм. 8:27;

Ифер 8:22–24;

С ба Г 87:7.

11а Хил. 6:31.

б Морм. 8:28–41;

С ба Г 33:4.

12а Сур. үгс 28:25.

13а Хил. 4:12.

б Езек. 34:8.

в Алма 5:53.

14а Сур. үгс 21:4.

б Иса. 53:6.

15а сү Бардамнал.

б Сур. үгс 3:5–7.

в 3 Ниф. 29:5.

16 Хий хоосны төлөө шударгыг “буцаах мөн сайны эсрэг арцалдах, мөн энэ нь чухал бус гэж хэлэх тэдэнд халаг! Учир нь Их Эзэн Бурхан дэлхийн оршин суугчдад гэнэт айлчлах тэр өдөр ирэх болно; мөн тэд алдаст ^ббүрэн боловсорсон тэр өдөр тэд мөхөх болно.

17 Гэвч болгоогтун, хэрэв дэлхийн оршин суугчид өөрсдийн ёс бус явдлууд мөн жигшүүрт хэргүүдээсээ наманчилбаас тэд устгагдахгүй байх болно хэмээн Түмний Их Эзэн хэлжээ.

18 Гэвч болгоогтун, тэр агуу хийгээд жигшүүрт сүм, бүх дэлхийн “садар эм, газарт ^бшурган унах ёстой, мөн түүний уналт агуу байх ёстой.

19 Учир нь чөтгөрийн хаант улс “салгалах ёстой, мөн үүнд харъяалагдах тэд наманчлалд өдөөн хатгагдах ёстой нь зайлшгүй, эс тэгвээс ^бчөтгөр тэднийг өөрийн үүрдийн ^бгинжээр боймлож, мөн тэд уур хилэнд өдөөгдөж мөн мөхөх болно.

20 Учир нь болгоогтун, тэр өдөр тэрээр хүмүүний үрсийн зүрхэнд “улангасч, мөн сайн болох түүний эсрэг тэднийг уурлуулан өдөөх болно.

21 Мөн бусад заримыг тэрээр “тайтгаруулж, мөн зуурдын аюулгүй байдалд тэднийг

тайвшруулахад, тэд: Сионд бүх юм зүгээр; тийм ээ, Сион дэгжинэ, бүх юм зүгээр гэнэ— мөн ^бчөтгөр тийн тэдний бодгалийг хуурч, мөн тэднийг болгоомжтойгоор там уруу удирдах болно.

22 Мөн болгоогтун, тэрээр бусад заримыг зусардан, мөн тэдэнд “там гэж үгүй хэмээн хэлдэг; мөн тэрээр тэдэнд: Би бол чөтгөр биш, учир нь тийм юм гэж үгүй гэдэг— мөн тэрээр тэднийг чөлөөлөгдөх нь үгүй өөрийн аймшигт ^бгинжээр хүлж автлаа хүмүүний үрсэд чихэнд нь тийн шивнэх болно.

23 Тийм ээ, тэд үхэлд, мөн тамд боймлогдсон; мөн үхэл, болон там, мөн сайхь чөтгөр, мөн түүгээр шүүрэгдсэн тэд бүгд Бурханы сэнтийний өмнө зогсож, мөн үйлүүдийнхээ дагуу “шүүгдэх ёстой, тэндээс тэд өөрсөддөө бэлтгэгдсэн тэр газарт очих ёстой, бүр төгсгөлгүй тарчлал болох тэрхүү хүхрийн чулуут мөн ^бгалт нуурт болой.

24 Тиймийн тул, Сионд сэрэмжгүй байгч түүнд халаг!

25 Бүх юм зүгээр гэж хашгирах түүнд халаг!

26 Тийм ээ, хүмүүний зааврыг “анхааран сонсдог, мөн Бурханы хүчийг, мөн Ариун Сүнсний бэлгийг үгүйсгэдэг түүнд халаг!

16a Иса. 29:21.

б Ифер 2:9–10.

18a Илч. 19:2.

б 1 Ниф. 14:3, 17.

19a 1 Ниф. 22:23.

б Алма 34:35.

в Алма 12:11.

20a С ба Г 10:20–27.

21a Морм. 8:31.

б 2 Ниф. 9:39.

22a су Там.

б Алма 36:18.

23a су Есүс Христ—

Шүүгч; Эцсийн шүүлт.

б 2 Ниф. 9:16, 19, 26.

26a 2 Ниф. 9:29.

27 Тийм ээ, ийн хэлдэг: бид хүлээн авчихсан, мөн бидэнд илүү “хэрэггүй хэмээн хэлэх түүнд халаг!

28 Мөн чухамдаа, Бурханы үнэний учир “уурлах, мөн салгалах тэд бүгдэд халаг! Учир нь болгоогтун, ^бхадан дээр баригдсан тэр нь үүнийг баяртайгаар хүлээн авдаг; мөн элсэн суурин дээр баригдсан тэр нь унах болуузай хэмээн айж салгалах ажгуу.

29 Бид Бурханы үгийг хүлээн авсан, мөн Бурханаас “өөр үг бидэнд ^бхэрэггүй, учир нь бидэнд хангалттай буй гэж хэлэх түүнд халаг!

30 Их Эзэн Бурхан хэлэв: Учир нь болгоогтун, би хүмүүний үрст шат шатаар, дүрэм “дүрмээр, энд бяцхан мөн тэнд бяцханыг өгөх болно; мөн миний дүрмүүдийг анхааран сонсох, мөн миний зааварт чих тавих тэд адислагдсан болой, учир нь тэд ^бмэргэн ухаанд суралцах болно; өөрөөр хэлбэл “хүлээн авах түүнд би ^вилүүг өгөх болно; мөн бидэнд хангалттай буй хэмээн хэлэх тэднээс бүр тэдэнд байгаа нь ч авагдах болно.

31 Хүмүүнд итгэдэг, эсвээс маханбодиос бүтэх гартаа “итгэдэг, эсвээс Ариун Сүнсний хүчээр өгөгдөх тэдний

заавруудаас гадна бол хүмүүний заавруудыг анхааран сонсдог тэд зүхэгдсэн болой.

32 Харийнханд “халаг түмний Их Эзэн Бурхан хэлдэг хэмээн! Учир нь би мутраа өдрөөс өдөрт тэдэнд сунгах хэдий ч, тэд намайг үгүйсгэх болно; Их Эзэн Бурхан хэлсэн нь, гэсэн хэдий ч хэрэв тэд наманчилж мөн надад ирэх аваас би тэдэнд нигүүлсэнгүй хандах болно; өөрөөр хэлбэл миний ^бмутар бүх өдрийн туршид сунгаастай байх болно хэмээн Түмний Их Эзэн Бурхан хэлдэг.

БҮЛЭГ 29

Олон харийнхан Мормоны Номыг эсэргүүцэх болно—Тэд бидэнд илүү Библи хэрэггүй хэмээх болно—Их Эзэн олон үндэстэнд ярьдаг—Тэрээр бичигдэх тэрхүү номуудаас энэ дэлхийг шүүх болно. Ойролцоогоор мээ 559–545 он.

Гэвч болгоогтун, олон нь байх болно—би хүмүүний үрстэй хийсэн өөрийн “гэрээнүүдийг санаж болохын тулд, Израилын угсаа болох өөрийн хүмүүсийг буцааж авахын тулд би мутраа ^бхоёр дахь удаагаа дахин хөдөлгөж болохын

27a Алма 12:10–11.

28a 2 Ниф. 9:40; 33:5.
су Эсэргүүцэл.

б Мат. 7:24–27.

су Хад.

29a 2 Ниф. 27:14;

Ифер 4:8.

б 2 Ниф. 29:3–10.

30a Иса. 28:9–13;

С ба Г 98:12.

б су Мэргэн Ухаан.

в Лук 8:18.

г Алма 12:10;

С ба Г 50:24.

31a С ба Г 1:19–20.

32a 1 Ниф. 14:6.

б Иаков 5:47; 6:4.

29 1a су Абрахамын
Гэрээ.

б 2 Ниф. 6:14;
21:11–12; 25:17.

су Израил—

Израилын

цугларалт.

тулд би тэдний дунд “гай-хамшигт ажил хийхээр зорих тэрхүү өдөр буюу;

2 Мөн түүнчлэн, би та нарын үр удмыг санана хэмээн Нифай чамд, мөн түүнчлэн чиний эцэгт амласнаа санаж болохын тулд; мөн таны үр удмын “үгс чиний үр удамд чинь миний амаар шилжин ирэх болно; мөн миний үгс дэлхийн өнцөг булан бүрд, Израилын угсаа болох миний хүмүүст ^бдалбаа болж ^висгэрэх болно;

3 Мөн миний үгс исгэрэн ирэх учир — харийнханаас олон нь хэлнэ: Ай “Библи! Ай Библи! Бидэнд Библи байгаа билээ, мөн өөр ямар ч Библи байж болохгүй.

4 Гэвч Их Эзэн Бурхан тийн хэлэв: Ай мунхгууд, тэд Библи тэй байх болно; мөн энэ нь миний эртний гэрээт хүмүүс болох “иудейчүүдээс гарч ирэх болно. Мөн тэднээс хүлээж авсан тэр ^бБиблийн учир “иудейчүүдэд тэд хэрхэн талархах билээ? Тийм ээ харийнхан ямар бодолтой билээ? Тэд харийнханд авралыг авчрахын тул иудейчүүдийн тарчлалыг мөн хөдөлмөрийг, мөн шаналлыг, мөн тэдний надад хандсан хичээнгүйллийг санадаг уу?

5 Ай харийнхан та нар, та нар миний эртний гэрээт хүмүүс иудейчүүдийг санасан уу? Үгүй; харин та нар тэднийг зүхэн, мөн тэднийг “үзэн ядсан, мөн тэднийг буцаан авчрахыг эрэлхийлээгүй. Гэвч болгоогтун, би эдгээр бүх зүйлийг та нарын өөрсдийн тань тэргүүн дээр эргүүлэх болно; учир нь Их Эзэн би өөрийн хүмүүсийг мартаагүй.

6 Мунхаг та нар, ийн хэлдэг: Ай “Библи, бидэнд Библи байгаа, мөн бидэнд өөр ямар ч Библи хэрэггүй. Иудейчүүдээр бус аваас та нар Библийг олох байсан гэж үү?

7 Та нар нэгээс илүү үндэстнүүд байдгийг мэдэхгүй гэж үү? Би, Их Эзэн та нарын Бурхан бүх хүмүүнийг “бүтээсэн, мөн би далайн ^барлууд дээрх тэднийг санахыг, мөн би дээр тэнгэрт мөн доор газарт захирдгийг; мөн би өөрийн үгийг хүмүүний үрст, тийм ээ, бүр дэлхийн бүх үндэстний дээр авчрах тэр мөн гэдгийг та нар эс мэднэ гэж үү?

8 Иймийн тул бувтналдах та нар, миний үгээс ихийг хүлээн авахын учир юм уу? “Хоёр үндэстний ^бгэрчлэл би бол Бурхан, би нэг үндэстний адил нөгөөг ч санахыг та нарт

1в 2 Ниф. 27:26.
су Сайн Мэдээний сэргээлт.

2а 2 Ниф. 3:18–21.

б 1 Ниф. 21:22.
су Туг.

в Иса. 5:26;

2 Ниф. 15:26;

Моро. 10:28.

3а 1 Ниф. 13:23–25.

су Библи;
Мормоны Ном.

4а С ба Г 3:16.

б су Иудей—Иудейн Саваа.

в су Иудейчүүд.

5а 3 Ниф. 29:8.

6а 1 Ниф. 13:38.

7а су Бүтээх, Бүтээл.

б 1 Ниф. 22:4.

8а Езек. 37:15–20;

1 Ниф. 13:38–41;

2 Ниф. 3:12.

б Мат. 18:16.

су Гэрч.

гэрчилж буйг та нар эс мэднэ гэж үү? Иймийн тул, нэг үндэстний адил нөгөө үндэстэнд би адил үгсийг ярьдаг болой. Мөн хоёр “үндэстэн хамтран нэгдэх үед хоёр үндэстний гэрчлэл түүнчлэн хамтран нэгдэх болно.

9 Мөн би бол өчигдөр, өнөөдөр, мөн үүрд нэгэн “адил; мөн би өөрийн үгсийг тааллынхаа дагуу ярьдгийг олонд баталж болохын тулд би үүнийг хийдэг. Мөн би нэг ^бүг ярьсан учир та нар намайг өөрийг хэлж чадахгүй хэмээн бодсоны хэрэггүй; өөрөөр хэлбэл миний ажил хараахан дуусаагүй байна; басхүү энэ нь хүмүүний төгсгөл хүртэл ийн байх нь үгүй, мөн тэр цагаас мөн үүрд дуусахгүй байх болно.

10 Иймийн тул, та нарт Библи буй хэдий ч та нар энэ нь миний бүх “үгсийг тээсэн гэж бодох хэрэггүй; бас та нар би өөрийг бичүүлсэн байх учиргүй хэмээн бодох хэрэггүй.

11 Өөрөөр хэлбэл би “бүх хүмүүнд, өрнөдөд мөн дорнодод аль алинд нь, мөн өмнөдөд бас умардад мөн далайн арлуудад, тэд миний тэдэнд ярих тэдгээр үгсийг ^ббичихийг зарлиг болгодог; өөрөөр хэлбэл бичигдэх тэр “номнуу-

даас би дэлхийг, “шүүнэ, хүн бүрийг тэдний үйлүүдийнх нь дагуу, бичигдсэн түүний дагуу болой.

12 Учир нь болгоогтун, би “иудейчүүдэд ярьж мөн тэд үүнийг бичих болно; мөн би түүнчлэн нифайчуудад ярих болно мөн тэд үүнийг ^ббичих болно; мөн түүнчлэн өөрийн гадагш удирдсан тэр Израилын угсааны бусад овгуудад би ярих болно, мөн тэд үүнийг бичих болно; мөн би түүнчлэн дэлхийн ^ббүх үндэстнүүдэд ярих болно, мөн тэд үүнийг бичих болно.

13 Мөнхүү улиран тохиох дор “иудейчүүдэд нифайчуудын үгс байх болно, мөн нифайчуудад иудейчүүдийн үгс байх болно; мөн нифайчууд мөн иудейчүүдэд Израилын ^балдагдсан овгуудын үгс байх болно; мөн Израилын алдагдсан овгуудад нифайчууд хийгээд иудейчүүдийн үгс байх болно.

14 Мөнхүү улиран тохиох дор Израилын “угсааных болох миний хүмүүс өөрсдийн эзэмшлийн нутагт, гэртээ цуглуулагдах болно; мөн миний үг түүнчлэн ^бнэгд цуглуулагдах болно. Мөн миний үгийн эсрэг мөн Израилын “угсааных болох миний

8в Хосеа 1:11.

9а Евр. 13:8.

б су Илчлэлт.

10а су Судрууд—Ирнэ хэмээн бошиглогдсон судрууд.

11а Алма 29:8.

б 2 Тим. 3:16.

в су Амьдралын Ном.

г 2 Ниф. 25:22; 33:11, 14–15.

су Эцсийн шүүлт.

12а 1 Ниф. 13:23–29.

б 1 Ниф. 13:38–42;

2 Ниф. 26:17.

в 2 Ниф. 26:33.

13а Морм. 5:12–14.

б су Израил—

Израилын алдагдсан арван овог.

14а Иер. 3:17–18.

б Езек. 37:16–17.

в 1 Ниф. 22:8–9.

хүмүүсийн эсрэг тулалдах тэдэнд, би бол Бурхан мөн би ‘үр удмыг нь ^оүүрд санана хэмээн Абрахамтай би ^ггэрээ хийснийг үзүүлэх болно.

БҮЛЭГ 30

Хөрвүүлэгдсэн харийнхан гэрээт хүмүүнтэй хамт тоологдох болно — Олон лемэнчүүд мөн иудейчүүд үгэнд итгэж мөн бахдам сайхан болох ажгуу — Израил сэргээгдэж, ёсон бусыг үйлдэгсэд устгагдах болно. Ойролцоогоор мээ 559–545 он.

Мөн эдүгээ болгоогтун, хайрт ах дүү нар минь, би та нарт ярья: учир нь би, Нифай, та нар харийнханы байдгаас илүү зөв шударга хэмээн бодохыг тань зөвшөөрөхгүй. Учир нь болгоогтун, та нар Бурханы зарлигуудыг дагахгүй бол та бүгд ч бас тийнхүү эрсдэх болно; мөн яригдсан үгсийн учир та нар харийнхан бүрмөсөн устгагдсан хэмээн бодох хэрэггүй.

2 Учир нь болгоогтун, харийханаас наманчлах болгон нь Их Эзэний ^ггэрээт хүмүүс гэдгийг би та нарт хэлье; мөн ^биудейчүүдээс наманчлахгүй олон нь зайлуулагдах болно; учир нь ^внүглээ наманчилж мөн Израилын Ариун Нэгэн болох, түүний Хүүд итгэх

тэднээс өөр хэнтэй ч Их Эзэн гэрээ хийхгүй болой.

3 Мөн эдүгээ, би иудейчүүд болон харийнханы талаар өөр зарим зүйлийг бошиглох сон. Өөрөөр хэлбэл миний ярьсан уг ном гарч ирэн мөн харийнханд бичигдэн мөн Их Эзэнд дахин лацдагдсаны дараа, бичигдсэн тэдгээр үгсэд “итгэх нь олон байх болно; мөн ^бтэд тэдгээрийг манай үр удмын үлдэгдэлд дамжуулах болно.

4 Мөн чингээд бидний үр удмын үлдэгдэл бидний талаар, бид хэрхэн Иерусалимаас гарч ирснийг, мөн тэд Иудейн удам болохыгоо мэдэх болно.

5 Мөн Есүс Христийн сайн мэдээ “тэдний дунд тунхаглагдах болно; иймийн тул, ^бтэд эцэг өвгөдийнхөө ^вмэдлэгт, мөн түүнчлэн эцэг өвгөдийнхөө дунд байсан Есүс Христийн тухай мэдлэгт сэргээгдэх болно.

6 Мөн чингээд тэд баясна; учир нь энэ нь Бурханы мутраас тэдэнд ирэх адислал гэдгийг тэд мэдэх болно; мөн тэдний харанхуйн тортог мэлмийгээс нь унаж эхлэх болно; мөн тэд цэвэр “ариун мөн бахдам сайхан хүмүүс байхаас бусдаар, олон үе тэдний дунд улиран одохгүй болой.

7 Мөнхүү улиран тохиох дор бусниулагдсан тэдгээр

14г С ба Г 132:30.

д Эхл. 17:7.

е Эхл. 12:1–3;

1 Ниф. 17:40;

3 Ниф. 20:27;

Абр. 2:9.

су Абрахамын Гэрээ.

30 2а Гал. 3:26–29.

б Мат. 8:10–13.

в су Иудейчүүд.

г су Наманчлах,

Наманчлал.

3а 3 Ниф. 16:6–7.

б 1 Ниф. 22:8–9.

5а 3 Ниф. 21:3–7, 24–26.

б С ба Г 3:20.

в 1 Ниф. 15:14;

2 Ниф. 3:12;

Морм. 7:1, 9–10.

6а С ба Г 49:24; 109:65.

“иудейчүүд түүнчлэн Христэд итгэж ^бэхлэх болно; мөн тэд уг нутгийн гадаргуу дээр цуглаж эхлэх болно; мөн Христэд итгэх болгон нь түүнчлэн бахдам сайхан хүмүүс болох бөлгөө.

8 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Бурхан дэлхий дээрх өөрийн хүмүүсийн сэргээлтийг гүйцэлдүүлэхийн тулд өөрийн ажлыг бүх үндэстэн, ястан, хэлтэн, мөн хүмүүсийн дунд эхлэх болно.

9 Мөн “Их Эзэн Бурхан зөв шударгаар ядууг ^бшүүж, мөн дэлхийн ^нномхон дөлгөөнчүүдийн төлөө тэгш эрхтэйгээр зэмлэл хүлээлгэх болно. Мөн тэрээр үгэн саваагаараа дэлхийг цохино; мөн уруул давах амьсгаагаар тэр ёсон бусыг үйлдэгчдийг хөнөөх болно.

10 Өөрөөр хэлбэл Их Эзэн Бурхан агуу “ялгалтыг хүмүүсийн дунд гүйцэтгэж мөн ёсон бусыг үйлдэгчдийг тэрээр устгах тэрхүү ^бцаг гэнэт ирнэ; мөн тэрээр өөрийн хүмүүсийг ^нхэлтрүүлэх болно, тийм ээ, хэрэв тэрээр ёсон бусыг үйлдэгсдийг түймрээр ‘устгах ёстой байсан ч адил буюу.

11 Мөн “зөв шударга байдал түүний хэвлийн тус бүслэгдэж, мөн итгэлт байдал

түүний ташаан тус бүслэгдэх болно.

12 Мөн чингээд чоно хургатай хамт “орших болно; мөн ирвэс ишигтэй хамт хэвтэж, мөн тугал, мөн залуу арслан, мөн зулзага хамтдаа байна; мөн бяцхан хүүхэд тэднийг хариулах болно.

13 Мөн үнээ болон баавгай цуг идэжлэн, үр төл нь хамтдаа хэвтэх болно; мөн арслан шар лугаа адил дэрс идэх болно.

14 Мөн хөхүүл хүүхэд наж могойн нүхэн дээр тоглох болно, мөн бойжсон хүүхэд гараа хорт могойн үүрэн дээр тавих болно.

15 Тэд миний бүх ариун ууланд гэмтэх хийгээд устгах нь үгүй; учир нь тэнгис усаар бүрхэгдсэн мэт газар дэлхий Их Эзэний мэдлэгээр дүүргэгдэх болно.

16 Иймийн тул, “бүх үндэстний зүйлүүд илэрхий болгогдох болно; тийм ээ, бүх зүйл хүмүүний үрсэд ^билэрхий болгогдох болно.

17 “Илчлэгдэхээс гадуур нууц байх нь үгүй; гэрэлд үзүүлэгдэхээс гадуур ямар ч харанхуйн ажил гэж үгүй байна; мөн дэлхий дээр нээгдсэнээс гадуур ямар ч битүүмжлэгдсэн нь байхгүй болно.

18 Иймийн тул, хүмүүний

7а 2 Ниф. 29:13–14.

б 2 Ниф. 25:16–17.

9а Иса. 11:4–9.

б 2 Ниф. 9:15.

в су Номхон

дөлгөөн, Номхон

дөлгөөн байдал.

10а С ба Г 63:53–54.

б су Эцсийн өдрүүд,

Хожмын өдрүүд.

в Мосе 7:61.

г 1 Ниф. 22:15–17, 23.

су Дэлхий—

Дэлхийн цэвэршилт.

11а Иса. 11:5–9.

12а Иса. 65:25.

су Мянган жил.

16а С ба Г 101:32–35;

121:28–29.

б Ифер 4:6–7.

17а С ба Г 1:2–3.

үрсэд илчлэгдсэн тэдгээр бүх зүйл тэр өдөр илчлэгдэх болно; мөн Сатан хүмүүний үрсийн зүрхийг давах хүчийг “удаан хугацааны турш эзэмшихгүй байх болно. Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, би өөрийн хэлэхийг төгсгөл болгоё.

БҮЛЭГ 31

Христ яагаад баптисм хүртсэнийг Нифай хэлэв — Хүмүүс аврагдахын тулд Христийг дагаж, баптисм хүртэж, Ариун Сүнснийг хүлээн авч, мөн эцсээ хүртэл тэвчих ёстой — Наманчлал болон баптисм нь давчуу бөгөөд нарийн замын хаалга болой — Баптисм хүртсэний дараа зарлигуудыг дагах тэдэнд мөнх амьдрал ирдэг. Ойролцоогоор мээ 559–545 он.

Мөн эдүгээ би, Нифай, та нарт “бошиглохоо төгсгөл болгоё, хайрт ах дүү нар минь. Мөн гарцаагүй улиран тохиох ёстойг нь би мэдэх тэр цөөн зүйлээс бусдыг би бичиж чадахгүй; бас миний дүү Иаковын үгсээс цөөн хэдээс бусдыг нь би бичиж чадахгүй.

2 Иймийн тул Христийн “сургаалын талаар миний ярих ёстой цөөн үгсээс гадна бол миний бичсэн зүйлүүд надад хангалттай; иймийн тул, би та нарт тодорхойгоор,

бошиглолынхоо бүрэн тодорхой байдлын дагуу ярих болно.

3 Учир нь тодорхой байдалд бодгаль минь баяснам; өөрөөр хэлбэл энэ маягаар Их Эзэн Бурхан хүмүүний дунд ажил хийдэг болой. Өөрөөр хэлбэл Их Эзэн Бурхан оюун ухаанд “гэрэл өгдөг; өөрөөр хэлбэл тэрээр хүмүүнд өөрсдийнх нь “хэлний дагуу тэдэнд ойлгогдохоор ярьдаг.

4 Иймийн тул, энэ дэлхийн нүглүүдийг зайлуулах ёстой “Бурханы Хурганд баптисм хүртээвэл зохих тэр, Их Эзэн надад үзүүлсэн сайхь “бошиглогчийн талаар та нарт миний ярьсныг та нар санаасай хэмээнэ би.

5 Мөн эдүгээ, хэрэв Бурханы Хурга, ариун тэрээр, бүх зөв шударгыг гүйцэлдүүлэхийн тулд усаар “баптисм хүртэх хэрэгтэй байсан аваас, Ай тэгвэл, ариун бус бид, баптисм хүртэх нь хичнээн илүү хэрэгтэй билээ, тийм ээ, бүр усаар шүү!

6 Мөн эдүгээ, би, та нараас асууя, хайрт ах дүү нар минь, Бурханы Хурга баптисм хүртсэнээр бүх зөв шударгыг хэрхэн гүйцэлдүүлэх билээ?

7 Тэр бээр ариун байсныг та нар мэдэхгүй гэж үү? Гэвч тэр ариун байсан боловч, маханбодийн дагуу тэрээр Эцэгийн өмнө өөрийгөө даруусгахаа,

18а Илч. 20:1–3;
Ифер 8:26.

31 1а 2 Ниф. 25:1–4.

2а 2 Ниф. 11:6–7.

3а су Гэрэл, Христийн

гэрэл.

б С ба Г 1:24.

4а су Бурханы Хурга.

б 1 Ниф. 10:7; 11:27.

су Иохан Баптист.

5а Мат. 3:11–17.

су Баптисм,

Баптисм хүртээх.

мөн тэрээр түүний зарлигуудыг дагахаар түүнд “дуулгавартай байх болно гэдгээ Эцэгт гэрчлэхээ хүмүүний үрст үзүүлсэн юм.

8 Иймийн тул, тэрээр баптисм хүртсэний дараа Ариун Сүнс түүний дээр “тагтаа ^бхэлбэрээр бууж ирсэн бөлгөө.

9 Мөн үүнчлэн, энэ нь хүмүүний үрст тэдний орох ёстой замын давчууг, мөн “хаалганы нарийныг үзүүлдэг, тэдний өмнө тэрээр үлгэрлэн үзүүлсний учир болой.

10 Мөн тэрээр хүмүүний үрст: Та нар намайг “дагагтун хэмээсэн бөлгөө. Иймийн тул, хайрт ах дүү нар минь, бид Эцэгийн зарлигуудыг сахихдаа бэлэн байхаас бусдаар бид Есүсийг ^бдагаж чадах уу?

11 Мөн Эцэг хэлэхдээ: Наманчил та нар, наманчил та нар, мөн миний Хайрлагдсан Хүүгийн нэрээр баптисм хүртэгтүн гэжээ.

12 Мөн түүнчлэн, Хүүгийн дуу хоолой надад ирж, хэлрүүн: Миний нэрээр баптисм хүртэх тэрээр, надад өгсний адилаар Эцэг түүнд Ариун Сүнс “өгөх болно; иймийн тул, намайг ^бдага, мөн миний хийхийг харсан тэр зүйлүүдээ хий хэмээжээ.

13 Иймийн тул, хайрт ах дүү

нар минь, хэрэв та нар бүх зүрх сэтгэлээрээ Бурханы өмнө хоёр нүүр гаргах мөн мэхлэхийг үл үйлдэн, харин үнэн санаатайгаар Хүүг даган, нүглүүдээ наманчлан, Эцэгт та нар “баптисмаар Христийн нэрийг өөрсдийн дээр авахад бэлэн байгаагаа гэрчлэн — тийм ээ, өөрсдийн Их Эзэн мөн өөрсдийн Аврагчийг усанд доош дагаж орвол, түүний үгийн дагуу, болгоогтун, чингээд та нар Ариун Сүнсийг хүлээн авах болно; тийм ээ, тэгээд галын мөн Ариун Сүнсний ^ббаптисм ирэх бөлгөө; мөн чингээд та нар тэнгэр элчүүдийн “хэлээр ярьж, мөн Израилын Ариун Нэгэнд магтаалыг хашгиран хэлж чадахыг би мэднэ.

14 Гэвч, болгоогтун, хайрт ах дүү нар минь, Хүүгийн дуу хоолой надад тийн ирж, хэлсэн нь: Та нар нүглүүдээ наманчилж, мөн баптисм хүртсэнээр, миний зарлигуудыг сахихад бэлэн буйгаа Эцэгт гэрчилж, мөн Ариун Сүнсний мөн галын баптисм хүлээн авч, мөн шинэ хэлээр тийм ээ, бүр тэнгэр элчүүдийн хэлээр ярьж чадах болсныхоо дараа, мөн үүний дараа намайг “үгүйсгэх аваас,

7a Иохан 5:30.

су Дуулгавартай байх, Дуулгавартай, Дуулгавартай дагах.

8a су Тагтааны тэмдэг.

б 1 Ниф. 11:27.

9a 2 Ниф. 9:41;

3 Ниф. 14:13–14;

С ба Г 22:4.

10a Мат. 4:19; 8:22; 9:9.

б Моро. 7:11;

С ба Г 56:2.

12a су Ариун Сүнсний бэлэг.

б Лук 9:57–62;

Иохан 12:26.

13a Гал. 3:26–27.

б су Ариун Сүнсний бэлэг; Гал.

в 2 Ниф. 32:2–3.

14a Мат. 10:32–33;

Алма 24:30;

С ба Г 101:1–5.

су Уучлагдашгүй нүгэл.

намайг мэдэхгүй байсан нь та нарт ^бдээр байх болно.

15 Мөн би Эцэгээс дуу хоолойг сонссон, өгүүлсэн нь: Тийм ээ, миний Хайртай нэгний үгс үнэн мөн итгэмжлэгдсэн бөлгөө. Эцсийг хүртэл тэвчсэн тэр нь, мөнхүү тэр нь аврагдах болно.

16 Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, үүгээр хүмүүн амьд Бурханы Хүүгийн “жишээг дагахдаа эцсээ хүртэл ^бтэвчихээс бусдаар бол, тэр аврагдаж чадахгүйг би мэднэ.

17 Иймийн тул, та нарын Их Эзэн мөн та нарын Гэтэлгэгчийн хийхийг миний харсан та нарт миний хэлсэн тэр зүйлийг хий; учир нь та нар орох ёстой тэр хаалгаа мэдэж болохын тулд, энэ шалтгааны учир, тэдгээр нь надад үзүүлэгдсэн билээ. Тухайлбал та нарын орох ёстой хаалга нь наманчлал мөн усаар хийгдэх “баптисм болой; мөн тэгээд Ариун Сүнсээр мөн галаар та нарын нүглүүдийн ^бангирал ирэх бөлгөө.

18 Мөн чингээд та нар энэхүү мөнхийн амьдралд хүргэдэг “давчуу бөгөөд нарийн ^бзамд байх болно; тийм ээ, та нар хаалгаар орсон бөлгөө; та нар Эцэг мөн Хүүгийн

зарлигуудын дагуу хийсэн буюу; мөн хэрэв та нар уг замаар орвол та нар хүлээж авна хэмээн түүний өгсөн амлалт гүйцэлдэж, та нар Эцэг мөн Хүүг ^бгэрчилдэг Ариун Сүнсийг хүлээж авсан билээ.

19 Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, та нарыг энэ давчуу бөгөөд нарийн замд орсны дараа, бүгд “хийгдсэн эсэхийг би асууя? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй; учир нь аврах чадал бүхий түүний гавьяанд та нар бүрэн дүүрнээр ^бдаатган, түүнд хэлбэрэлтгүй ^битгэлтэйгээр Христийн үгсээр бус аваас өдий зэрэгт хүрээгүй болой.

20 Иймийн тул, та нар “найварын төгс гэрэлтэйгээр, мөн Бурханыг болон бүх хүмүүнийг хайрлах ^бхайрыг агуулан Христэд тууштайгаар итгэн “урагш тэмүүлэх ёстой. Иймийн тул, хэрэв та нар урагш тэмүүлэн, Христийн үгнээс зооглон, мөн эцсээ хүртэл ^бтэвчих аваас, болгоогтун, Эцгийн ийн хэлсэнчлэн: Та нарт мөнх амьдрал байх болно.

21 Мөн эдүгээ, болгоогтун, хайрт ах дүү нар минь, “зам нь энэ; мөн хүмүүн Бурханы хаант улсад аврагдаж чадах

14б 2 Петр 2:21.

16а су Есүс Христ—
Есүс Христийн
улгэр Жишээ.

б Алма 5:13; 38:2;
С ба Г 20:29.

17а Мозая 18:10.

су Баптисм,

Баптисм хүртээх.

б су Нүглүүдийн

ангирал.

18а 1 Ниф. 8:20.

б Сур. үгс 4:18.

су Зам.

в Үйлс 5:29–32.

19а Мозая 4:10.

б С ба Г 3:20.

в су Итгэл.

20а су Найдвар.

б су Хайр.

в су Аллах,

Бурхантай хамт
аллах.

г су Тэвчих.

21а Үйлс 4:10–12;

2 Ниф. 9:41;

Алма 37:46;

С ба Г 132:22, 25.

өөр тийм өгөгдсөн ^бнэр болон ^азам гэж тэнгэрийн дор үгүй. Мөн эдүгээ, болгоогтун, энэ нь Христийн ^ссургаал мөн төгсгөлгүй ^ннэг Бурхан болох ^эЭцэгийн болон Хүүгийн, мөн Ариун Сүнсний үнэн бөгөөд цорын ганц сургаал болой. Амен.

БҮЛЭГ 32

Тэнгэр элчүүд Ариун Сүнсний хүчээр ярьдаг—Хүмүүн залбиран мөн Ариун Сүнснээс өөрсөддөө мэдлэг авах ёстой. Ойролцоогоор мээ 559–545 он.

Мөн эдүгээ, болгоогтун, хайрт ах дүү нар минь, та нар уг замаар орсныхоо дараа та нар юу хийх ёстой талаараа зүрх сэтгэлдээ хэсэг зуур тунгааж буй хэмээн би сэтгэнэ. Гэвч, болгоогтун, та нар юуны учир эдгээр зүйлүүдийг зүрх сэтгэлдээ тунгаана вэ?

2 Та нар Ариун Сүнс “хүлээн авсныхаа дараа та нар тэнгэр элчүүдийн ^бхэлээр ярьж чадна хэмээн миний хэлснийг та нар санахгүй байна уу? Мөн эдүгээ, Ариун Сүнсээр бус бөгөөс та нар яаж тэнгэр элчүүдийн хэлээр ярьж чадах билээ?

3 “Тэнгэр элчүүд Ариун Сүнсний хүчээр ярьдаг; иймийн тул, тэд Христийн

үгсийг ярьдаг. Иймийн тул, би та нарт хэлсэнчлэн, Христийн үгэн дээр ^бнайрла, учир нь болгоогтун, Христийн үгс та нарын хийвэл зохих бүх зүйлийг та нарт хэлэх болно.

4 Иймийн тул, эдүгээ би эдгээр үгсийг ярьсны дараа, хэрэв та нар эдгээрийг ойлгож эс чадах аваас энэ нь та нар “асуудаггүй, бас тогшдоггүйн учир болой; иймийн тул, та нар гэрэлд авчрагдсангүй, харин харанхуйд мөхөх ёстой.

5 Учир нь болгоогтун, би та нарт дахин хэлье, хэрэв та нар уг замд орох, мөн Ариун Сүнсийг хүлээн авбаас, энэ нь та нарын хийвэл зохих тэр бүх зүйлийг та нарт үзүүлэх болно.

6 Болгоогтун, энэ нь Христийн сургаал, мөн тэрээр өөрийгөө та нарт бие махбодид үзүүлсний дарааг хүртэл ямар ч өөр сургаал өгөгдөхгүй байх болно. Мөн тэрээр өөрийгөө бие махбодид “үзүүлэхэд, та нарт түүний хэлэх зүйлийг та нар хийхийг хичээгтүн.

7 Мөн эдүгээ би, Нифай, илүүг хэлж чадахгүй; Сүнс миний дууг зогсоож, мөн хүмүүний “итгэлгүй, мөн ёсон бус, мөн үл мэдэх, мөн зөрүүдийн учир би гашуудан хоцрох бууу; учир нь мэдлэг тэдэнд ^бтодорхой байдалд, бүр үгээр хэрхэн тодорхой

21б су Есүс Христ—
Өөрсөд дээрээ Есүс
Христийн нэрийг
авах.

^в Мозая 3:17.

^г Мат. 7:28;

Иохан 7:16–17.

д 3 Ниф. 11:27, 35–36.
су Эв нэгдэл.

е су Бурхан, Бурхан
тэргүүтэн.

32 2а 3 Ниф. 9:20.

б 2 Ниф. 31:13.

3а су Тэнгэр элчүүд.

б Иер. 15:16.

4а су Асуух.

6а 3 Ниф. 11:8.

7а су Итгэлгүй
байдал.

б 2 Ниф. 31:2–3;

Иаков 4:13.

байж болох тэр хэмжээгээр өгөгдөхөд тэд үүнийг үл эрэлхийлэн мөн агуу мэдлэгийг үл ойлгох авай.

8 Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, та нар зүрх сэтгэлдээ тунгаасаар буйг би ухамсарлаж байна; мөн би энэ зүйлийн талаар ярих ёстой болсон нь намайг гонсойлгож байна. Учир нь хэрэв та нар хүмүүнд залбирахыг сургах Сүнснийг анхааран аваас, та нар “залбирах ёстойг мэдэх бөлгөө; өөрөөр хэлбэл ^бхилэнцэт сүнс хүнд залбирахыг үл сургана, харин тэрээр залбирах ёсгүйг түүнд сургадаг.

9 Гэвч болгоогтун, та нар үргэлж “залбирах ёстойг мөн шантрах ёсгүйг би та нарт хэлье; та нарын үйл бодгальд тань ^бзолтой байж болохын тулд тэр та нарын үйлийг та нарт ариулахын тулд юун түрүүнд та нар Христийн “нэрээр Эцэгт залбирахаас өөр нэгээхэн ч зүйлийг Их Эзэнд үйлдэх ёсгүй.

БҮЛЭГ 33

Нифайн үгс үнэн—Тэдгээр нь Христийг гэрчилдэг—Шүүхийн тавцангийн өмнө гэрч болон зогсох Нифайн үгсэд Христэд итгэдэг тэд итгэх болно. Ойролцоогоор мэө 559–545 он.

Мөн эдүгээ би, Нифай, миний хүмүүсийн дунд сургагдсан бүх зүйлийг бичиж чадахгүй; бас би бичихдээ ярихынхаа адил “бузгай нэгэн биш; учир нь хүн Ариун Сүнсний хүчээр ^бярихад Ариун Сүнсний хүч үүнийг хүмүүний үрсийн зүрх сэтгэлд хүргэдэг.

2 Гэвч болгоогтун, Ариун Сүнсний эсрэг зүрх сэтгэлээ “хатууруулдаг нь олон буйн учир, энэ нь тэдэнд орших зайгүй болой; иймийн тул, тэд бичигдсэн тэдгээрээс олон зүйлийг хаяж мөн тэдгээрийг хоосон зүйлүүд мэт үнэлдэг болой.

3 Гэвч би, Нифай, өөрийн бичсэнийг бичсэн мөн энэ нь ялангуяа миний хүмүүст агуу “чухал зүйл хэмээн би үнэлдэг. Учир нь би тэдний төлөө өдрөөр үргэлж ^бзалбиран мөн шөнөөр нүд минь дэрийг минь норгодог, тэдний учир болой; мөн би Бурхандаа итгэлтэйгээр гуйн залбирч, мөн тэр гуйлтыг минь сонсохыг би мэднэ.

4 Мөн Их Эзэн Бурхан миний хүмүүсийн тусын тулд залбирлуудыг минь ариулан адислах болно гэдгийг би мэднэ. Мөн миний сул доройдоо бичсэн тэдгээр үгс тэдэнд “хүчтэй болгогдох болно; учир нь энэ нь тэднийг сайныг хийхэд ^бятгадаг

8а су Залбирал.

б Мозая 4:14.
су Чөтгөр.

9а 3 Ниф. 20:1;

С ба Г 75:11.

б Алма 34:27.

в Мосе 5:8.

33 1а Ифер 12:23–24.

б С ба Г 100:7–8.

2а Хил. 6:35–36.

3а су Судрууд—

Судруудын үнэ

цэнэ.

б Инос 1:9–12;

Мор. үгс 1:8.

4а Ифер 12:26–27.

б Моро. 7:13.

болой; энэ нь эцэг өвгөдийнх нь талаар тэдэнд мэдүүлдэг; мөн энэ нь Есүсийн тухай өгүүлж, мөн тэднийг түүнд итгэхийг, мөн “мөнх амьдрал болох эцсийг хүртэл тэвчийг ятгдаг бөлгөө.

5 Мөн энэ нь нүглийн эсрэг үнэний “тодорхой байдлын дагуу, “хатуугаар ярьдаг; иймийн тул, ямар ч хүмүүн, тэр нь чөтгөрийн сүнснийх байхаас гадуур бол миний бичсэн үгсэд уурлах нь үгүй болой.

6 Би тодорхой байдлыг бахаднам; би үнэнийг бахаднам; би өөрийн Есүсийг бахаднам, учир нь тэр бодгалийг минь тамаас “гэтэлгэсэн билээ.

7 Би өөрийн хүмүүст “энэрлийг, мөн би түүний шүүхийн суудалд толбогүйгээр олон сүнстэй уулзана хэмээн Христэд итгэх агуу итгэлийг агуулна.

8 Би “Иудейд энэрлийг агуулна—би өөрийн ирсэн тэндээс тэднийг хамааруулан хэлж буй учир Иудей хэмээнэ би.

9 Би түүнчлэн “харийханд энэрлийг агуулах болно. Гэвч болгоогтун, тэд Христэд “нийцсэн байж, амьдралд хүргэх тэр нарийн “хаалгаар орж

мөн “давчуу замаар “алхан, мөн сорилтын өдрийн эцсийг хүртэл уг замыг үргэлжлүүлэхээс бусдаар бол би тэдгээрийн нэгээхний нь ч төлөө би найдаж чадахгүй бөлгөө.

10 Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, мөн түүнчлэн Иудей, мөн дэлхийн өнцөг булан бүр та нар бүгд, эдгээр үгсийг анхааран сонсож мөн Христэд “итгэ; мөн хэрэв та нар эдгээр үгсэд үл итгэх аваас, Христэд итгэ. Мөн хэрэв та нар Христэд итгэх болбоос та нар эдгээр “үгсэд итгэх болно, учир нь эдгээр нь Христийн “үгс, мөн тэрээр эдгээрийг надад өгсөн юм; мөн эдгээр нь тэд сайныг хийвэл зохихыг бүх хүмүүнд “заадаг билээ.

11 Мөн хэрэв эдгээр нь Христийн үгс биш аваас, та нар шүүн тунгаа—өөрөөр хэлбэл Христ та нарт эцсийн өдөр, эдгээр нь түүний үгс гэдгийг агуу их сүр жавхлан хийгээд “хүчээр үзүүлэх болно; мөн та нар болон би түүний “тавцангийн өмнө нүүр нүүрээрээ тулан зогсох болно; мөн би сул дорой хэдий ч, эдгээр зүйлийг бичихийг би түүгээр зарлигдуулсныг та нар мэдэх болно.

4в су Мөнх амьдрал.

5а 2 Ниф. 31:3;

Иаков 4:13.

б 1 Ниф. 16:1–3;

2 Ниф. 9:40.

6а су Гэтэлгэх,

Гэтэлгэгдэх,

Гэтэлгэл.

7а су Энэрэл.

8а су Иудейчүүд.

9а су Харийнхан.

б су Цагаатгах,

Цагаатгал.

в 2 Ниф. 9:41.

г Хил. 3:29–30;

С ба Г 132:22.

д су Алхах,

Бурхантай хамт

алхах.

10а су Итгэлтэй байх,

Итгэл.

б су Мормоны Ном.

в Моро. 10:27–29.

г 2 Ниф. 25:28.

11а Ифер 5:4;

Моро. 7:35.

б Илч. 20:12;

Моро. 10:34.

12 Мөн би Христийн нэрээр Эцэгт, хэрэв бүгд бус бол, бидний олон нь тэрхүү агуу их хийгээд эцсийн өдөр, түүний “хаант улсад аврагдаж болно хэмээн залбирдаг.

13 Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, Израилын угсааных болох тэд бүгд, мөн дэлхийн хязгаарууд та нар бүгд, би та нарт газар шорооноос “хашгирах нэгний дуугаар: Тэр агуу их өдрийг ирэх хүртэл сайныг хүсье хэмээн хэлж байна.

14 Мөн Бурханы сайн сайх-

ныг эс хүртэх, мөн иудейчүүдийн “үгсийг, мөн түүнчлэн миний ⁶үгсийг, мөн Бурханы Хурганы амнаас гарах үгсийг үл хүндлэх та нар, болгоогтун, би та нарт үүрдийн хагацлын өмнө сайныг хүсье, учир нь эдгээр үгс эцсийн өдөр та нарыг “буруутгах болно.

15 Учир нь дэлхий дээр миний лацадсан нь, “шүүхийн тавцан дээр та нарын эсрэг авчрагдах болно; учир нь Их Эзэн надад тийн зарлигласан, мөн би дагах ёстой. Амен.

ИАКОВЫН НОМ

НИФАЙН ДҮҮ

Ах нартаа номлосон түүний үгс оршвой. Тэрбээр Христийн сургаалыг сүйрүүлэхийг эрэлхийлэгч хүмүүнийг гутаав. Нифайн хүмүүсийн түүхийн талаарх хэдэн үг оршвой.

БҮЛЭГ 1

Христэд итгэж мөн түүний зарлигуудыг дагахыг хүмүүнд ятгахыг Иаков Иосеф хоёр эрэлхийлэв—Нифай нас нөгчив—Нифайчуудын дунд ёсон бусын үйлс тархав. Ойролцоогоор мэв 544–421 он.

УЧИР нь болгоогтун, улиран тохиох дор Лихай

Иерусалимыг орхисон цагаас тавь бас таван жил улиран одов; иймийн тул, “Иаков надад, эдгээр зүйлийг дээр нь сийлбэрлэсэн, ⁶жигжиг ялтсуудын талаар “зарлигийг Нифай өгсөн болой.

2 Мөн тэрбээр Иаков надад, би эдгээр ялтсууд дээр хамгийн үнэт байна хэмээн өөрийн эргэцүүлсэн зүйлүүдээс цөөн хэдийг нь бичвэл

12а су Селестиел алдар суу.

13а Йса. 29:4;
2 Ниф. 26:16.

14а су Библи.
б су Мормоны Ном.

в 2 Ниф. 29:11;
Ифер 4:8–10.

15а Мор. үгс 1:11.
[Иаков]

1 1а су Иаков, Лихайн хүү.

б 2 Ниф. 5:28–33;
Иаков 3:13–14.

су Ялтсууд.
в Иаков 7:27.

зохихыг, Нифайн хүмүүс гэж нэрлэгдсэн энэ хүмүүсийн түүхийн талаар өнгөцхөн дурдахаас бусдаар хүрч эс болохыг зарлигласан билээ.

3 Учир нь тэрбээр түүний хүмүүсийн түүх түүний бусад ялтсууд дээр сийлэгдсэн байвал зохихыг, мөн би эдгээр ялтсуудыг хадгалан үлдээж мөн тэднийг үр удамдаа үеэс үед гардуулан өгвөл зохихыг хэлсэн бөлгөө.

4 Мөн хэрэв ариун нандин гэгдсэн номлол, эсвээс агуу гэгдсэн илчлэлт, эсвэл бошиглол байх аваас, эдгээр ялтсууд дээр тэдгээрийн “гол чухлыг нь сийлбэрлэн, мөн тэдгээрийн талаар аль болох ихийг Христийн тулд, мөн өөрсдийн хүмүүсийн тусын тулд тухайлан бичиглэхийг болой.

5 Өөрөөр хэлбэл итгэлийн мөн агуу зовнилын учир, бидэнд өөрсдийн хүмүүсийн талаар, тэдэнд чухам юу “тохиолдох талаар үзүүлэгдсэн болой.

6 Мөн түүнчлэн бид олон илчлэлт, мөн их бошиглолын суу билигтэй байлаа; иймийн тул, ирэх ёстой “Христийн, мөн түүний хаант улсын талаар бид мэдсэн билээ.

7 Иймийн тул тэд Израилын

хүүхдүүдийг “аглаг буйдад байхад уруу таталтын өдрүүдийн үеийн 6 өдөөн хатгалтын адилаар тэд 6 орох нь зохисгүй хэмээн өөрийн хилэгнэлд түүнийг зүхэх вий хэмээн Христэд 7 ирж, мөн Бурханы сайн сайхныг хүртэж болно хэмээн, тэд түүний 8 амралтад орж болно хэмээн бид тэднийг ухуулж болохын тулд, бид өөрсдийн хүмүүсийн дунд шаргуугаар хөдөлмөрлөсөн бөлгөө.

8 Иймийн тул, бид бүх хүмүүнийг, Бурханыг “уурлуулахаар түүний эсрэг 9 ээсэргүүцэхгүй байхыг ятгаж чаддаг ч болоосой, харин бүх хүмүүн Христэд итгэж, мөн түүний үхлийг тунгааж, мөн түүний “загалмайг үүрэлцэж бас дэлхийн шившгийг хуваалцаасай хэмээн Бурханд хандана; иймийн тул, би, Иаков, өөрийн ах Нифайнхаа зарлигийг биелүүлэхийг өөрийн биед хүлээх ажгуу.

9 Эдүгээ Нифай өндөр настай болж эхлэв, мөн тэрбээр өөрийгөө удахгүй “наснаас халих ёстойг мэдэв; иймийн тул, тэрээр 6 хаадын засаглауудын дагуу, эдүгээ өөрийн хүмүүсийн дээр удирдагч мөн хаан байх хүнийг 6 тослон адисалсан бөлгөө.

4а ө.х. Тэргүүн зэргийн, чухал зүйлүүд.

5а 1 Ниф. 12.

6а 1 Ниф. 10:4–11; 19:8–14.

7а Тоол. 26:65;

1 Ниф. 17:23–31.

б Евр. 3:8.

в Тоол. 14:23; Дэд хууль 1:35–37; С ба Г 84:23–25.

г 2 Ниф. 9:41;

Омнаи 1:26;

Моро. 10:32.

д су Амрах.

8а 1 Ниф. 17:30;

Алма 12:36–37;

Хил. 7:18.

б су Эсэргүүцэл.

в исо, Мат. 16:25–26;

Лук 14:27.

9а 2 Ниф. 1:14.

б 2 Ниф. 6:2;

Жером 1:7.

в су Томилох.

10 Хүмүүс Нифайг үлэмж хайрладаг байв, тэрбээр тэдэнд агуу өмгөөлөгч болж, тэднийг хамгаахын тулд Лебений “илдийг эзэмшиж, мөн бүх өдрүүддээ тэдний тусын тулд хөдөлмөрлөж байсны учир бөлгөө.

11 Иймийн тул, хүмүүс түүний нэрийг санан хадгалах хүсэлтэй байв. Мөн түүний оронд засагласан хэн боловч хүмүүсээр, хоёрдугаар Нифай, гуравдугаар Нифай, мөн цаашлан, хаадын засаглалуудын дагуу нэрлэгдсэн ажээ; мөн тэдний нэр хэн байснаас үл хамааран, хүмүүсээр тэд тийн нэрлэгдсэн бөлгөө.

12 Мөнхүү улиран тохиох дор Нифай нас нөгчив.

13 Эдүгээ хүмүүс “леменчүүд бус аваас ^бнифайчууд гэгдэх болов; гэсэн хэдий ч тэд нифайчууд, иаковчууд, иосефчууд, ^взорамчууд, леменчүүд, лемүелчүүд, мөн ишмэилчүүд хэмээн нэрлэгддэг байв.

14 Харин би, Иаков, цаашид тэднийг эдгээр нэрүүдээр онцлохгүй, харин Нифайн хүмүүсийг устгахыг эрэлхийлэх тэднийг леменчүүд гэж “нэрлэн, мөн Нифайд нөхөрсөг байдаг тэднийг ^бнифайчууд, эсвээс ^вНифайн хүмүүс

хэмээн нэрлэх болно, хаадын засаглалуудын дагуу болой.

15 Эдүгээ мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүс, хоёр дахь хааны засаглалын дор, зүрх сэтгэлдээ хатууг агуулж, мөн эртний Давид, мөн түүнчлэн түүний хүү Соломон нарын олон “эхнэр болон татвар эмсийг хүссэнчлэн, ёсон бус дадлуудад өөрсдийгөө өөгшүүлж эхэлсэн бөлгөө.

16 Тийм ээ, мөн тэд түүнчлэн маш их алт болоод мөнгийг эрж эхлэв, мөн бардамналдаа зарим талаар ихэрхэх болж эхлэв.

17 Иймийн тул би, Иаков, эхлээд өөрийн “даалгаврыг Их Эзэнээс аваад, ^бариун сүмд би тэдэнд сургахдаа эдгээр үгсийг тэдэнд өгсөн бөлгөө.

18 Учир нь би, Иаков, мөн миний дүү Иосеф, энэ хүмүүсийн санваартнууд хийгээд багш нар болж Нифайн гараар “ариулан адислагдсан билээ.

19 Мөн бид Их Эзэнд өөрсдийн “албан тушаалд хичээнгүйлэн зүтгэх, ^бүүрэг хариуцлагыг өөрсдийн дээр авч, хэрэв бид тэдэнд бүх чадлаараа хичээнгүйлэн Бурханы үгийг заагаагүй аваас

10a 1 Ниф. 4:9;
2 Ниф. 5:14;
Мор. үгс 1:13;
Мозая 1:16;
С ба Г 17:1.

13a Инос 1:13;
С ба Г 3:18.
б су Нифайчууд.
в 1 Ниф. 4:35;
4 Ниф. 1:36–37.

14a Мозая 25:12;
Алма 2:11.
б 2 Ниф. 4:11.
в 2 Ниф. 5:9.
15a С ба Г 132:38–39.
17a су Дуудах,
Бурханаас
дуудагдах,
Дуудлага.
б 2 Ниф. 5:16.

су Ариун Сүм, Их
Эзэний Өргөө.
18a 2 Ниф. 5:26.
19a су Албан тушаал,
Албан тушаалтан.
б С ба Г 107:99–100.
су Даамал, Ажил
үүрэг.

хүмүүний нүглийг толгой дээрээ хүлээх буюу; иймийн тул, өөрсдийн хүчээр хөдөл-мөрлөснөөр тэдний цус бид-ний өмсгөл дээр ирэхгүй байж болох буюу; эс бөгөөс тэдний “цус бидний өмсгөл дээр ирж, мөн бид эцсийн өдөр толбогүй байж эс чадах болно.

БҮЛЭГ 2

Баялаг, бардамнал, мөн ариун бус явдалд дурлахыг Иаков буруушаав—Хүмүүн бусдадаа туслахын тулд баялгийг эрэлхийлэх болно—Иаков зөвшөөрөгдөөгүй олон эхнэртэй байх явдлыг буруутгав—Их Эзэн эмэгтэйчүүдийн ариун явдалд баясдаг. Ойролцоогоор мээ 544–421 он.

Нифайн дүү Иаков, Нифайг нас барсны дараа Нифайн хүмүүст ярьсан тэрхүү үгс оршвой.

2 Эдүгээ, хайрт ах дүү нар минь, Иаков, би, Бурханы өмнө хүлээсэн хариуцлагынхаа дагуу өөрийн албан тушаалд хичээнгүйлэн зүтгэж, мөн би өмсгөлөө та нарын нүглүүдээс ангижруулж болно хэмээн, би энэ өдөр та нарт Бурханы үгийг тунхаглаж болохын тулд ариун сүм өөд та нар дээр ирлээ.

3 Мөн би дуудлагынхаа албан тушаалд өдийг хүртэл хичээнгүй байсныг та нар өөрсдөө мэднэ; гэвч би энэ

өдөр өдийг хүртэл байснаас үлэмж илүүгээр та нарын бодгалиудын аз жаргалын төлөө хүсэл тэмүүлэл хийгээд зовнилдоо дарагдан байна.

4 Учир нь болгоогтун, эдүгээ болтол, миний та нарт өгсөн, Их Эзэний үгэнд та нар дуулгавартай байсан билээ.

5 Гэвч болгоогтун, намайг анхааран сонсогтун, мөн тэнгэр болон газрыг Бүтээгч бүхнийг чадагч түүний тусламжаар та нарын “бодлуудын талаар миний хувьд машид жигшүүрт гэгдэх, тийм ээ, мөн Бурханд ч жигшүүрт болох тэр нүгэлд та нар хэрхэн замнаж эхэлж байгааг би хэлж чадна.

6 Тийм ээ, зүрх сэтгэлийн тань ёсон бусын талаар би та нарт гэрчлэх ёстой болов, энэ нь миний сэтгэлийг гонсойлгож мөн өөрийн Бий Болгогчийн оршихуйн өмнө намайг ичсэнээс нугдайхад хүргэж байна.

7 Мөн түүнчлэн Бурханд таалагдах зүйл болох Бурханы өмнө олон нь үлэмж энхрий болоод “ариун мөн эмзэг мэдрэмж бүхий тэдгээр эхнэр мөн хүүхдүүдийн чинь өмнө би та нарын талаарх яриандаа маш их “шулууныг хэрэглэх ёстой болов, энэ нь намайг гонсойлгож байна.

8 Мөн тэд Бурханы таалалт “үгийг сонсохоор нааш ирсэн хэмээн надад бодогдов, тийм

ээ, шархадсан зүрх сэтгэлийг эдгээгч тэрхүү үгийг болой.

9 Иймийн тул, тэдний шархыг эдгээж мөн тайтгаруулахын оронд, аль хэдийн шархалсан тэдгээрийн шархыг сэдэрээх, та нарын гэмт хэргүүдийн дагуу та нарт сэрэмжлүүлэн сануулахаар, Бурханаас миний хүлээн авсан чанд зарлигийн учир, би албадуулах болсон нь зүрх сэтгэлийг минь хүндрүүлнэ; мөн шархлаагүй тэдэнд Бурханы таалалт үгсээс зооглохын оронд тэдний сүнсийг цоо хатгахаар мөн тэдний эмзэг оюуныг шархлуулахаар чинжаал хутгууд дүрэгдэх болой.

10 Гэвч, уг үүрэг агуу хэдий ч, би Бурханы чанд “зарлигуудын дагуу үйлдэж мөн сэтгэлийн цэвэрт мөн харууссан зүрхэт тэдний дэргэд, мөн Бүхнийг Чадагч Бурханы ^бцоо ширтэх мэлмийн харцан доор өөрсдийн чинь ёсон бус мөн жигшүүрт хэргүүдийн чинь талаар та нарт хэлэх ёстой.

11 Иймийн тул, Бурханы үгийн “тодорхой байдлын дагуу би үнэнийг та нарт хэлэх ёстой. Учир нь болгоогтун, Их Эзэнээс хүссэний минь дагуу, уг үг надад ийн ирж, хэлсэн нь: Иаков, маргааш ариун сүм өөд яв, мөн чамд миний өгөх үгийг энэ хүмүүст тунхагла.

12 Мөн эдүгээ болгоогтун, ах

дүү нар минь, та нарт миний тунхаглах тэрхүү үг энэ болой, та нарт болон та нарын үр удамд “амлалтын нутаг болох тэр, энэхүү нутагт элбэг дэлбэгээр бялхах алт, мөн мөнгө, бас бүх төрлийн үнэт ^бхүдрийг та нарын олонх нь эрж хайж эхэлсэн бөлгөө.

13 Мөн хангагч ариун мутар та нарын дээр ихэд тааламжтайгаар инээмсэглэж байсны учир та нар олон баялгийг эзэмшсэн билээ; мөн та нарын зарим нь ах дүүсээсээ илүү баялгийг эзэмшсэний учир та нар зүрх сэтгэлийн бардамналд “өргөгдөж, мөн зөрүүдлэн дээгүүр хардаг учир нь та нарын өмсгөл чимэг үнэтэйн учир болой, мөн та нар өөрсдийгөө тэднээс илүү хэмээн бодох учир ах дүүсээ хавчих бөлгөө.

14 Мөн эдүгээ, ах дүүс минь, Бурхан та нарыг энэ зүйлд чинь зөвтгөнө хэмээн бодно уу? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй. Харин тэр та нарыг буруушаана, мөн хэрэв та нар эдгээр зүйлүүдэд энэ хэвээрээ үлдэх аваас түүний шүүлтүүд та нар дээр гэнэт ирэх ёстой.

15 Ай тэрбээр та нарыг цоо хатгаж, та нарыг мэлмийнхээ ганц харцаар тоос болтол цохьж чадахаа тэрбээр үзүүлээсэй!

16 Ай тэрбээр та нарын энэ алдас мөн жигшүүрт хэргээс

10а су Бурханы зарлигууд.

б 2 Ниф. 9:44.

11а 2 Ниф. 25:4; 31:2–3.

12а 1 Ниф. 2:20.

су Амлалтын нутаг.

б 1 Ниф. 18:25;

Хил. 6:9–11;

Ифер 10:23.

13а Морм. 8:35–39.

та нарыг ангижруулаасай. Мөн, Ай та нар түүний зарлигуудын үгийг сонсож, мөн та нарын зүрхний энэ “бардамнал бодгалийг тань устгахыг бүү зөвшөөрөөсэй!

17 Өөрсдийнхөө нэгэн адил ахан дүүсээ бод, мөн “тэд та нарын адил баян байж болохын тулд бүгдтэй нөхөрсөг, бас ^бхөрөнгөөрөө өгөөмөр сэтгэлтэй бай.

18 Харин та нар “баялгуудыг эрэлхийлэхийн өмнө, Бурханы ^бхаант улсыг эрэлхийлэгтүн та нар.

19 Мөн та нар Христэд найдах найдварыг олсныхоо дараа хэрэв та нар тэдгээрийг эрэлхийлэх аваас, та нар баялгуудыг олох болно; мөн та нар тэдгээрийг “сайныг үйлдэх зорилгын төлөө эрэлхийлэх болно — нүцгэнийг хувцаслахад, мөн өлссөнийг хооллоход, бас боолчлогдсоныг чөлөөлөхөд, мөн өвдсөн бас зовсныг халамжлахад буюу.

20 Мөн эдүгээ, ах дүү нар минь, би та нарт бардамналын талаар ярьсан болой; мөн та нарт Бурханы өгсөн тэр зүйлүүдийн учир зүрхэндээ бардамналыг тээсэн учир хөршийгөө зовоож, мөн түүнийг хавчсан та нар үүнийхээ талаар юу хэлэх билээ?

21 Бүх маханбодийг бүтээсэн

түүнд ийм зүйлүүд жигшүүртэй хэмээн та нар бодохгүй юу? Мөн түүний хувьд нэг нь бусдын адил эрхэм болой. Мөн бүхий л маханбодь тоосных билээ; мөн тэрбээр тэд түүний “зарлигуудыг дагаж мөн түүнийг үүрд алдаршуулбал зохино гэсэн нэгэн адил зорилгын учир тэдгээрийг бүтээсэн ажгуу.

22 Мөн эдүгээ би энэхүү бардамналын талаар та нарт ярихаа төгсгөл болгоё. Мөн та нарт би үүнээс илүү жигшим гэмт хэргийн талаар ярих ёстой бус байсан аваас, миний зүрх сэтгэл та нарын учир үлэмж их баясах сан.

23 Гэвч та нарын илүү жигшим хэргүүдийн учир Бурханы үг намайг шаналгана. Учир нь болгоогтун, ийн Их Эзэн хэлэв: Энэ хүмүүс ёсон бусад уусч эхэлжээ; тэд судруудыг ойлгодоггүй, өөрөөр хэлбэл тэд шалиг завхайг үйлдэхдээ өөрсдийгөө зөвтгөхөөр эрэлхийлдэг, Давид мөн түүний хүү Соломоны талаар бичигдсэн байгаа тэдгээр зүйлүүдийн учир бөлгөө.

24 Болгоогтун, Давид “Соломон хоёр үнэхээр олон ^бэхнэр мөн татвар эмстэй байсан нь миний өмнө жигшүүрт зүйл болой хэмээн Их Эзэн хэлэв.

25 Иймийн тул, Их Эзэн ийн хэлэв, би өөртөө Иосефын

16a су Бардамнал.

17a 4 Ниф. 1:3.

б су Өглөг, Өглөг өгөх; Халамж.

18a Хаад. дээд 3:11–13;

Марк 10:17–27;

2 Ниф. 26:31;

С ба Г 6:7.

су Баялгууд.

б Лук 12:22–31.

19a Мозая 4:26.

21a С ба Г 11:20;

Абр. 3:25–26.

24a Хаад. дээд 11:1;

Нех. 13:25–27.

б Хаад. дээд 11:1–3;

Езра 9:1–2;

С ба Г 132:38–39.

хэвлийн үрээс “зөв шударга мөчрийг өсгөж болохын тулд би энэ хүмүүсийг өөрийн гараар Иерусалим газраас гаргаж удирдсан билээ.

26 Иймийн тул, Их Эзэн Бурхан бибээр энэ хүмүүс эрт цагийн тэдэнтэй адил үйлдэхийг тэвчихгүй.

27 Иймийн тул, ах дүүс минь, намайг сонсогтун, мөн Их Эзэний үгийг анхаарцгаа: Өөрөөр хэлбэл та нарын дунд хэн боловч “нэгээс илүү эхнэртэй байж үл болно; мөн тэрбээр татвар эмс нэгийг ч авах ёсгүй.

28 Учир нь би, Их Эзэн Бурхан, эмэгтэйчүүдийн “ариун явдалд баясдаг билээ. Мөн завхайрал нь миний өмнө жигшүүрт хэрэг; тийн Түмний Их Эзэн хэлдэг бөлгөө.

29 Иймийн тул, энэ хүмүүс миний зарлигуудыг дагах болно хэмээн Түмний Их Эзэн хэлэв, эсвээс уг нутаг тэдний үйлүүдийн улмаас “зүхэгдэг.

30 Учир нь хэрэв би, Түмний Их Эзэн, надад “үр удмыг өсгөхийг хүсвэл, би өөрийн хүмүүст зарлиглах болно; өөрөөр бол тэд эдгээр зүйлийг анхааран сонсох болно хэмээн хэлэв.

31 Учир нь болгоогтун, би, Их Эзэн, Иерусалимын газарт, тийм ээ, мөн миний

хүмүүсийн бүх нутгуудад, тэд эр нөхрүүдийнхээ ёсон бус хийгээд жигшүүрт хэргүүдийн улмаас миний хүмүүсийн охидын гашуудахыг сонсож, бас харамсахыг нь харсан билээ.

32 Мөн, Түмний Их Эзэн, би бээр Иерусалимын газраас удирдан гаргасан тэдгээр болох энэ хүмүүсийн хонгорхон охидын уйлааныг, миний хүмүүсийн эрчүүдийн эсрэг дээш надад ирэхийг би зөвшөөрөхгүй хэмээн Түмний Их Эзэн хэлэв.

33 Учир нь номхон сайхных нь улмаас тэд миний хүмүүсийн охидыг олзлон хөтлөхгүй, тэгвэл би тэдэнд зовлонт зүхлээр, бүр устгалд хүргэх түүгээр айлчлах болно; учир нь тэд “садар самууныг эрт цагийн тэдний адил үйлдэх ёсгүй, хэмээн Түмний Их Эзэн хэлэв.

34 Мөн эдүгээ болгоогтун, ах дүүс минь, эдгээр зарлигууд бидний эцэг Лихайд өгөгдсөнийг та нар мэднэ; иймийн тул, та нар тэдгээрийг урьд нь мэддэг байв; мөн та нар агуу буруутгалд унасан бөлгөө; учир нь та нар хийх нь зохисгүй зүйлийг үйлдсэн бөлгөө.

35 Болгоогтун, та нар өөрсдийн ах дүүс болох леменчүүдээс “илүүтэй алдсыг үйлдсэн бөлгөө. Та нар цэвэр эмзэг

25a Эхл. 49:22–26;
Амос 5:15; 2 Ниф. 3:5;
Алма 26:36.
су Лихай, Нифайн
эцэг.

27a С ба Г 42:22; 49:16.

су Гэрлэлт, Гэрлэх.
28a су Ариун явдал.
29a Ифер 2:8–12.
30a Малах. 2:15;
С ба Г 132:61–66.

33a су Тачаангуй,

Тачаангуй байдал;
Бэлгийн
харилцаанл ёс
суртахуунгүй
байдал.

35a Иаков 3:5–7.

эхнэрүүдийнхээ зүрхийг эмтэлж, мөн тэдний өмнө өөрсдийн муу жишээнүүдийн учир, хүүхдүүдийнхээ итгэлийг алдсан; мөн тэдний зүрхний мэгшилтүүд та нарын эсрэг Бурхан өөд дээш ирж байна. Мөн та нарын эсрэг доош ирэх Бурханы үг шулууны учир олон бодгаль гүнзгий шархнуудаас цоорч үхсэн билээ.

БҮЛЭГ 3

Зүрх сэтгэлдээ цэвэр тэд Бурханы таалалт үгийг хүлээж авдаг — Леменчүүдийн зөв шударга байдал нифайчуудынхаас давах бөлгөө — Иаков хууль бусаар эр эм бололцох явдал, шунаг тачаал, мөн нүгэл бүрийг эсэргүүцэн сэрэмжлүүлэв. Ойролцоогоор мээ 544–421 он.

Гэвч болгоогтун, Иаков, би, зүрх сэтгэлээрээ цэвэр байх та нарт ярихыг хүснэ. Бурханд шийдэмгий оюунаар хандаж, мөн түүнд үлэмж итгэлтэйгээр залбирагтун, мөн тэрбээр та нарыг зовлонд чинь тайтгаруулна, мөн тэрбээр та нарыг өмгөөлж, мөн та нарын устгалыг эрэлхийлэх тэдэнд шударга ёсыг доош илгээх болно.

2 Ай цэвэр зүрх сэтгэлтэй болох та нар бүгд, тэргүүнээ өргөгтүн, мөн Бурханы таалалт үгийг хүлээн авагтун, түүний хайран дээр найр-

лагтун; учир нь та нар, хэрэв та нарын оюун “шийдэмгий аваас, үүрд түүнчлэн байх болно.

3 Гэвч зүрх сэтгэл цэвэр бус, энэ өдөр Бурханы өмнө “бузар байгаа та нарт халаг, ай халаг; учир нь та нар наманчлахгүй аваас уг нутаг та нарын улмаас зүхэгдэх болно; мөн, та нарын адил бузар бус, гэсэн хэдий ч зовлонг зүхлээр ⁶зүхэгдсэн Леменчүүд, та нарыг бүр усталд чинь хүртэл цээрлүүлэх болно.

4 Мөн та нар наманчлахгүй аваас тэд та нарын өвлөсөн нутгийг эзэмшиж мөн Их Эзэн Бурхан та нарын дундаас зөв шударгыг үйлдэгчдийг “зайлуулан гаргаж удирдах тэр цаг удахгүй ирэх болно.

5 Болгоогтун, тэдний бузрынх нь мөн тэдний арьсанд ирсэн тэр зүхлийн учир та нарын үзэн яддаг, та нарын ахан дүүс болох тэдгээр леменчүүд, та нараас илүү зөв шударга; учир нь бидний эцэгт өгөгдсөн, тэд нэг эхнэртэй байх мөн тэд нэгээхэн ч татвар эмс авахгүй, мөн тэдний дунд завхайрал үйлдэгдэх ёсгүй хэмээх Их Эзэний зарлигийг тэд “мартаагүй юм.

6 Мөн эдүгээ, энэ зарлигийг дагахын төлөө тэд чармайдаг; иймийн тул, зарлигийг дагах энэхүү чармайлтын учир, Их Эзэн Бурхан тэднийг устгахгүй, харин тэдэнд “нигүүлсэнгүй байх болно; мөн нэгэн

3 2а Алма 57:26–27.
3а су Бузар, Бузар
явдал.

б 1 Ниф. 12:23.
4а Омнай 1:5–7, 12–13.
5а Иаков 2:35.

6а 2 Ниф. 4:3, 6–7;
Хил. 15:10–13.

өдөр тэд адислагдсан хүмүүс болно.

7 Болгоогтун, тэдний эр нөхрүүд эхнэрээ “хайрладаг, мөн тэдний эхнэрүүд эр нөхрөө хайрладаг; мөн тэдний эр нөхрүүд мөн тэдний эхнэрүүд хүүхдүүдээ хайрладаг; мөн тэдний итгэлгүй байдал, бас тэд та нарт хонзогнох нь эцэг өвгөдийнх нь алдсын улмаас бөлгөө; иймийн тул өөрсдийнхөө агуу их Бүтээгчийн мэлмийд та нар тэднээс яахан илүү дээр байх билээ?

8 Ай ах дүү нар минь, та нар нүглүүдээ наманчлахгүй болбоос та нар тэдэнтэй хамт Бурханы сэнтийн өмнө аваачигдах үед, тэдний арьс та нарынхаас илүү цагаан байх вий хэмээн би айнам.

9 Иймийн тул, Бурханы үг болох, миний та нарт өгөх зарлиг бол та нар тэдний арьс барааны улмаас тэднийг дахин эсэргүүцэн бүү доромжил; бас та нар тэдний бузрын учир тэднийг бүү эсэргүүцэн доромжил; харин та нар өөрсдөө өөрсдийнхөө бузар явдлыг санаж, мөн тэдний бузар явдал эцэг өвгөдийнх нь улмаас ирснийг сана.

10 Иймийн тул, та нар “хүүхдүүдээ, тэдний өмнө та нарын үзүүлсэн жишээний учир зүрх сэтгэлийг нь та нар хэрхэн гонсойлгож буйгаа

санах болно; мөн түүнчлэн, бузар явдлуудынхаа учир, хүүхдүүдээ устгалд авчирч, мөн тэдний нүглүүд эцсийн өдөр та нарын толгой дээр овоорч магадгүйг сана та нар.

11 Ай ах дүү нар минь, миний үгсийг сонсогтун; бодгалийнхаа чадварыг сэргээ; та нар үхлийн нойрноос “сэрж болохын тулд өөрсдийгөө сэгсэрцгээ; мөн хоёр дахь “үхэл болох хүхэрт чулуун болон галт нуурт хаягдаж, чөтгөрийн “элчүүд болохгүйн тулд өөрсдийгөө “тамын тарчла-лаас салга.

12 Мөн эдүгээ, Иаков, би, Нифайн хүмүүст илүү олон зүйлийг ярьж, “хууль бусаар эр эм бололцох хийгээд “тачаал, бас нүглийн зүйл болгоны эсрэг тэдэнд сануулж, тэдгээрийн аймшигт хор уршгийг тэдэнд хэллээ.

13 Мөн энэ хүмүүсийн эдүгээ тоолшгүй болж байгаа үйл хэргүүдийн зууны нэг хэсэг нь “эдгээр ялтсууд дээр бичигдэж чадахгүй; гэвч тэдний хэргүүдээс олон нь мөн тэдний дайнууд, мөн тэдний тэмцлүүд, мөн тэдний хаадын засаглалууд илүү том ялтсууд дээр бичигдсэн буй.

14 Эдгээр ялтсууд Иаковын ялтсууд хэмээн нэрлэгдэж, мөн тэдгээр нь Нифайн гараар хийгдсэн бөлгөө. Мөн би эдгээр үгсийг ярихаа төгсгөл болгоё.

7a су Гэр бүл; Хайр.
10a су Хүүхэд,
Хүүхдүүд.
11a Алма 5:6–9.

б су Сүнсний үхэл.
в 2 Ниф. 9:8–9.
г су Там.
12a су Садар самуун.

б су Тачаадах; Ёс бус,
Ёс бус явдал.
13a 1 Ниф. 19:1–4;
Иаков 1:1–4.

БҮЛЭГ 4

Бүх бошиглогчид Христийн нэрээр Эцэгийг бишрэн шүтсэн билээ—Абрахам Исаакаар тахил өргөх гэсэн нь Бурхан мөн түүний Төрсөн Ганц хүүг дүрсэлсэн ажээ—Хүмүүн нь Цагаатгалаар дамжуулан Бурханд өөрсдийгөө нийцүүлэх ёстой—Иудейчүүд суурийн чулуунаас татгалзах болно. Ойролцоогоор мээ 544–421 он.

Эдүгээ болгоогтун, улиран тохиох дор, Иаков, би, өөрийн хүмүүсийг үгэнд ихэд тохиуулсан, (мөн өөрсдийн үгсийг ялтсууд дээр сийлбэрлэхэд бэрхийн учир, би өөрийн үгсээс багахнаас бусдыг бичиж чадахгүй) мөн бид ялтсууд дээр бичсэн уг зүйлүүд хадгалагдан үлдэх ёстойг мэднэ;

2 Гэвч ялтсууд дээрхээс бусад бидний бичсэн зүйлүүд юу ч байсан эрсдэж мөн алга болох учиртай; харин хүүхдүүддээ, мөн түүнчлэн хайрт ах дүү нартаа, бидний талаар эсвээс тэдний эцэг өвгөдийн талаарх мэдлэгийн бяцхан хэсгийг өгөх цөөн үгийг ялтсууд дээр бид бичиж чадна—

3 Эдүгээ энэ зүйлд бид баясна; мөн бидний хайрт ах дүү нар болон хүүхдүүд маань тэдгээрийг талархсан сэтгэлээр хүлээн авна, мөн тэд

харамсалгүйгээр бас зэвүүцэлгүйгээр харин баясгалантайгаар анхны эцэг эхийнхээ талаар мэдэж болох учир тэдгээрийг харах буюу хэмээн найдаж, эдгээр үгсийг ялтсууд дээр сийлэхээр бид хичээнгүйлэн хөдөлмөрлөж буй бөлгөө.

4 Учир нь, бид Христийг “мэдсэн, мөн түүнийг ирэхээс олон зуун жилийн өмнө түүний сүр жавхланг хүлээн авах найдлага бидэнд байсныг тэд мэдэж болно хэмээн, бид эдгээр зүйлийг энэ зорилтын учир бичиглэсэн болой; мөн зөвхөн бид ч бус, харин биднээс өмнө байсан бүх ариун ⁶бошиглогчид түүнчлэн түүний сүр жавхланд найдаж байсан ажээ.

5 Болгоогтун, тэд Христэд итгэж мөн түүний нэрээр Эцэгийг “шүтэн биширч байв, мөн бид түүнчлэн түүний нэрээр Эцэгийг шүтэн биширдэг бөлгөө. Мөн энэ зорилтын учир бид ⁶Мосегийн хуулийг дагадаг, энэ нь бидний сэтгэл зүрхийг түүнд “хандуулдаг; мөн энэ шалтгааны улмаас энэ нь зөв шударга ёсны төлөө биднийг ариулсан, бүр энэ нь Бурхан болон түүний “Төрсөн Ганц Хүүгийн дүрслэл болох аглаг буйдад Абрахам Бурханы зарлигуудад дуулгавартай байхын тулд хүү Исаакаараа

4 аа су Есүс Христ.
б Лук 24:25–27;
Иаков 7:11;
Мозая 13:33–35;
С ба Г 20:26.

5а Мосе 5:8.
б 2 Ниф. 25:24;
Жером 1:11;
Мозая 13:27, 30;
Алма 25:15–16.

су Мосегийн хууль.
в Гал. 3:24.
г Эхл. 22:1–14;
Иохан 3:16–18.
су Цорын Ганц.

тахил өргөх гэсний шалтгаан байсан бөлгөө.

6 Иймийн тул, бид бошиглогчдыг судалж байв, мөн бидэнд олон илчлэлт болон “бошиглолын суу билиг байв; мөн бид эдгээр олон ^бнотолгоотой болсон учир найдлага олж, мөн итгэл маань гуйвшгүй болно, үүний хэрээр бид Есүсийн ^внэрээр ^гзарлиглаж чадаад мөн модод, бас уулс, бас далайн давалгаа бидэнд дуулгавартай байв.

7 Гэсэн хэдий ч, энэ нь түүний ач ивээл мөн хүмүүний үрсэд хандах түүний агуу их хүлцлээр бид эдгээр зүйлийг хийх хүчтэй гэдгийг бид мэдэж болохын тулд Их Эзэн Бурхан өөрсдийн маань ^асул доройг бидэнд үзүүлдэг болой.

8 Болгоогтун, Их Эзэний ажлууд агуу хийгээд гайхамшигтай юм. Түүний ^анууцуудын гүн нь хичнээн ^бтанигдашгүй билээ; мөн хүмүүн түүний бүхий л замуудыг олж мэдэх нь боломжгүй. Мөн түүнд илчлэгдээгүй аваас ямар ч хүмүүн түүний ^взамуудыг ^гүл мэднэ; иймийн тул, ахан дүүс минь, Бурханы илчлэлтүүдийг бүү басамжил.

9 Учир нь болгоогтун, дэлхийн гадаргуу дээр ^ахүмүүн түүний ^бүгийн хүчээр ирсэн юм, түүний үгийн хүчээр бүтээгдсэн тэрхүү дэлхийд шүү дээ. Иймийн тул, хэрэв Бурхан яриад дэлхийг тогтоож, бас яриад мөн хүмүүнийг бүтээж чадсан атал, Ай тэгвэл, яахан өөрийн зорилго мөн тааллын дагуу ^агазар дэлхийд, эсвээс үүний гадаргуу дээрх мутрынхаа бүтээлд зарлиглаж чадахгүй байх билээ?

10 Иймийн тул, ах дүүс минь, Их Эзэнд ^азөвлөхөөр бус, харин түүний мутраас зөвлөгөөг авахаар эрэлхийл. Учир нь болгоогтун, тэрбээр ^бмэргэн ухаанд, мөн шударга ёсонд, мөн агуу их нигүүлсэлд, өөрийн бүх ажлыг хамруулан зөвлөдгийг та нар өөрсдөө мэддэг шүү дээ.

11 Иймийн тул, хайрт ах дүү нар минь, түүний ^аТөрсөн Ганц Хүү, Христийн ^бцагаатгалаар түүнд нийцсэн бай, тэгвэл Христэд байх амилуулалтын хүчээр та нар ^вамилуулалтыг олж болно, мөн итгэлтэй байж, мөн түүнийг бие махбодид өөрийгөө үзүүлэхээс өмнө түүний сүр жавхлангийн сайн найдлагыг

6а су Бошиглох,
Бошиглол.

б су Гэрч.

в Уйлс 3:6–16;

3 Ниф. 8:1.

г су Хүч.

7а Ифер 12:27.

8а С ба Г 19:10; 76:114.

су Бурханы
нууцууд.

б Ром 11:33–36.

в Иса. 55:8–9.

г 1 Кор. 2:9–16;

Алма 26:21–22.

су Мэдлэг.

9а су Бүтээх, Бүтээл;

Хүн, Хүмүүс.

б Морм. 9:17;

Моце 1:32.

в Хил. 12:8–17.

10а 2 Ниф. 9:28–29;

Алма 37:12, 37;

С ба Г 3:4, 13.

б су Бүхнийг Мэдэгч;

Мэргэн ухаан.

11а су Цагаатгах,

Цагаатгал.

б Евр. 5:9.

в су Амилуулалт.

олж, мөн Бурханд Христийн 'анхны үр жимс хэмээн танилцуулагдах бөлгөө.

12 Мөн эдүгээ, хайрлагдсан та нар, би эдгээр зүйлийг та нарт хэлж байгаад бүү гайхагтун; өөрөөр хэлбэл яагаад амилуулалтын мөн ирэх ертөнцийн мэдлэгт хамаарах Христийн цагаатгалыг "ярихгүй мөн түүний төгс мэдлэгт хүрэхгүй байх билээ?"

13 Болгоогтун, ах дүү нар минь, бошиглох тэрээр, хүмүүний ойлголтын тулд бошиглог; өөрөөр хэлбэл "Сүнс хуурах нь үгүй, мөн үнэнийг хэлдэг. Иймийн тул, энэ нь үнэхээр тэдгээр зүйлүүдийг ^ббайгаагаар нь, мөн тэдгээр зүйлүүдийг үнэхээр байхаар нь ярьдаг; иймийн тул, эдгээр зүйлүүд, бидний бодгалиудын авралын тулд бидэнд "тодорхой үзүүлэгдсэн, билээ. Гэвч болгоогтун, зөвхөн бид эдгээр зүйлүүдийг гэрчилж байгаа бус; учир нь Бурхан түүнчлэн эртний бошиглогчдод тэдгээрийг ярьсан бөлгөө.

14 Гэвч болгоогтун, иудейчүүд "зөрүүд хүмүүс байв; мөн тэд тодорхой байдлын ^бүгсийг басамжилсан билээ; мөн бошиглогчдыг алсан, мөн тэд ойлгож чадаагүй зүйлүүдийнхээ төлөө эрэлхийлсэн

юм. Иймийн тул, уг зорилгоос алсуур хайснаас болсон тэр, "харалганыхаа учир тэд унах ёстой нь зайлшгүй; өөрөөр хэлбэл Бурхан тэднээс өөрийн тодорхой байдлыг зайлуулан авч, мөн тэднийг 'ойлгож чадахгүй тэрхүү олон зүйлийг тэдэнд илгээсэн ажээ, тэд үүнийг хүссэний учир буюу. Мөн тэд үүнийг хүссэн учир Бурхан үүнийг тэд бүдэрч болохын тулд хийсэн ажгуу.

15 Мөн эдүгээ би, Иаков, бошиглолд Сүнсээр удирдагдан байв; өөрөөр хэлбэл надад байх тэрхүү Сүнсний нөлөөгөөр иудейчүүдийн "бүдрэлийн улмаас, тэд дээр нь барьж болох ^бчулуунаас мөн аюулгүй суурьтай байхаас "татгалзах болно гэдгийг би ухаарч мэдсэн болой.

16 Гэвч болгоогтун, судруудын дагуу, энэ "чулуу нь иудейчүүд дээр нь барьж чадах тэр агуу их, мөн сүүлийн мөн цорын ганц тогтвортой ^бсуурь юм.

17 Мөн эдүгээ, хайрт та нар минь, энэ нь булангийн тулгуур болох магадгүй тэр тогтвортой сууринаас татгалзсаны дараа яаж үүн дээр "барих боломжтой байх билээ?"

18 Болгоогтун, хайрт ах дүү

11г Мозая 15:21–23; 18:9;
Алма 40:16–21.

12а 2 Ниф. 25:26.

13а су Ариун Сүнс;
Үнэн.

б С ба Г 93:24.

в Алма 13:23.

14а Мат. 23:37–38;
2 Ниф. 25:2.

б 2 Кор. 11:3;

1 Ниф. 19:7;

2 Ниф. 33:2.

в Иса. 44:18;

Ром 11:25.

г 2 Ниф. 25:1–2.

15а Иса. 8:13–15;

1 Кор. 1:23;

2 Ниф. 18:13–15.

б су Булангийн

тулгуур чулуу; Хад.

в 1 Ниф. 10:11.

16а Дуул. 118:22–23.

б Иса. 28:16;

Хил. 5:12.

17а Мат. 19:30;

С ба Г 29:30.

нар минь, энэ нууцыг би та нарт дэлгэе; хэрэв ямар нэгэн шалтгаанаар би, Сүнсэн дэх өөрийн шийдэмгий байдлаас ухрахгүй, мөн та нарын төлөөх үлэмж зовнилынхоо учир бүдрэхгүй аваас буюу.

БҮЛЭГ 5

Иаков таримал болон зэрлэг чидуны моддын ётлолтой холбож Зиносоос иш татав—Тэдгээр нь Израил болон харийнхантай адилтгагдсан аж—Израилын тараагдалт мөн цугларалт зөгнөгдөв—Нифайчууд болон леменчүүд мөн бүх Израилын угсааг ётлон хэлсэн ажгуу—Харийнхан Израилд залгаагдах болно—Эцэст нь жимсний талбай шатаагдах болно. Ойролцоогоор мэв 544–421 он.

Болгоогтун, ах дүү нар минь, Израилын угсаанд түүний ярьсан бошиглогч “Зиносын үгсийг уншсанаа та нар санахгүй байна уу, өгүүлсэн нь:

2 Анхаарагтун, Ай Израилын угсаа та нар, мөн Их Эзэний бошиглогч, миний үгсийг сонс.

3 Учир нь болгоогтун, Их Эзэн ийн хэлжээ, Ай “Израилын угсаа, би чамайг ^бусан үзмийн талбайдаа нэгэн хүний авч арчилсан, ^вчидуны таримал модтой адилтгана; мөн энэ нь ургаж, мөн өтлөөд, мөн ^гөмхөрч эхэлсэн буюу.

4 Мөнхүү улиран тохиох дор талбайн эзэн гарч, мөн тэрээр чидуны мод өмхөрч эхэлснийг харав; мөн тэрээр хэлэв: энэ нь залуу болон туяхан мөчрүүдийг гаргаж, мөн үхэхгүй байж болохын тулд би үүнийг тайрч, мөн эргэн тойронд нь сийрүүлж, мөн үүнийг арчилна.

5 Мөнхүү улиран тохиох дор тэр өөрийн үгийн дагуу үүнийг тайрч, мөн эргэн тойрныг нь сийрүүлж, мөн арчилсан аж.

6 Мөнхүү улиран тохиох дор олон өдрийн дараа энэ нь бага зэрэг цөөн хэдэн, залуу бас туяхан мөчрүүдийг гаргаж эхлэв; гэвч болгоогтун, үүний гол үхэж эхлэв.

7 Мөнхүү улиран тохиох дор талбайн эзэн үүнийг хараад, мөн тэрээр зарцдаа: би энэ модыг алдах ёстой болсон нь намайг гонсойлгож байна; иймийн тул, яваад мөн “зэрлэг чидуны модноос мөчрүүдийг нь тайрч мөн тэдгээрийг нааш авчир, мөн бид эдгээр хувхайрч эхэлсэн тэр гол мөчрүүдийг тасдаж авна, мөн бид эдгээр нь шатаагдаж болохын тулд эдгээрийг галд хаях болно.

8 Мөн болгоогтун, талбайн Эзэн хэлэв, би эдгээр залуу бөгөөд туяхан мөчрүүдээс олныг нь салган авч мөн эднийг хүссэн газартаа залган суулгах болно; мөн энэ

5 1а су Зенос.
3а Езек. 36:8.
су Израил.
б С ба Г 101:44.

су Их Эзэний
талбай.
в Ром 11:17–24.
су Чидуны мод.

г су Урвалт.
7а Ром 11:17, 24.

модны үндэс эрсдэх нь хамаагүй, би үр жимсийг нь өөртөө хадгалан үлдээж болно; иймийн тул, би эдгээр залуу мөн туяхан мөчрүүдийг авах болно, мөн би эдгээрийг хүссэн газраа залгах болно.

9 Чи зэрлэг чидуны модны мөчрүүдийг ав, мөн тэднийг эдний “оронд байранд нь залга; мөн эдгээр нь миний талбайд зай эзлэхгүй байхын тулд би тасдаж авсныгаа галд хаяж мөн шатаах болно.

10 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэний зарц, талбайн Эзэний үгийн дагуу үйлдэж, мөн “зэрлэг чидуны модны мөчрүүдийг залган суулгав.

11 Мөн талбайн Эзэн орчныг нь сийрүүлж, мөн засаж тайраад, мөн арчил хэмээгээд зарцдаа хэлсэн нь: Би энэ модыг алдах нь намайг гонсойлгоно; иймийн тул, эдгээр нь мөхөхгүй байж, би түүний үндсүүдийг хадгалан үлдээж болно хэмээн, би эдгээрийг өөртөө хадгалан үлдээж болох магад хэмээн би энэ зүйлийг хийсэн бөлгөө.

12 Иймийн тул, замаараа одогтун; миний үгсийн дагуу модыг харагтун, мөн үүнийг арчлагтун.

13 Мөн эдгээрийг би талбайнхаа хамгийн алсын хэсэгт хүссэн газраа “байрлуулна, хаана гэдэг нь чамд хамаагүй; мөн би модны унаган мөчрүүдийг өөртөө хадгалан үлдээж болохын тулд би үүнийг

хийнэ; мөн түүнчлэн, би өөртөө эдгээрийн үр жимсийг ирэх улиралд нөөцөлж болохын тулд хэмээв; учир нь би энэ модыг мөн үүний үр жимсийг алдах болсон нь намайг гонсойлгох бөлгөө.

14 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн замаараа явж, мөн талбайн алсын хэсгүүдэд таримал чидуны модны унаган мөчрүүдийг, өөрийн таалал мөн хүслийн дагуу заримыг нь нэгэнд мөн заримыг нь нөгөөд нууцалсан болой.

15 Мөнхүү улиран тохиох дор урт хугацаа өнгөрөн одож, мөн талбайн Эзэн зарцдаа: Ир, бид талбайд хөдөлмөрлөж болохын тулд, талбай уруу явцгаая хэмээв.

16 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн, мөн түүнчлэн сайхь зарц хөдөлмөрлөхөөр талбай уруу явцгаав. Мөнхүү улиран тохиох дор зарц эзэндээ: Болгоогтун, үүнийг хараач; модыг болгоо хэмээв.

17 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зэрлэг чидуны мөчрүүд залгагдсан мөнөөх модыг үзэж мөн болгоов; мөн энэ нь нахиалан “үр жимс өгч эхэлсэн байв. Мөн энэ нь сайн байсныг тэрээр болгоов; мөн жимс нь унаган жимсний адил байсан бөлгөө.

18 Мөн тэрээр зарцдаа хэлэв: Болгоогтун, зэрлэг модны мөчрүүд үндэснээсээ чийг авсан тул үндэс нь их хүч

гаргажээ; мөн тэдний үндэс нь их хүчирхэг учир зэрлэг мөчрүүд таримал жимс авчирсан ажээ. Эдүгээ, хэрэв бид эдгээр мөчрүүдийг залгаагүй байсан бол, тэр мод үхэх байсан. Мөн эдүгээ, болгоогтун, би уг модны авчирсан тэр их жимсийг хадгалах болно; мөн үүний жимсийг би өөртөө улирлын тулд нөөцлөх болно хэмээв.

19 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцад: Ирэгтүн, талбайн алсын хэсэг тийш явцгаая, мөн би үүний жимсийг дараагийн улиралд өөртөө нөөцөлж болохын тулд уг модны унаган мөчрүүд түүнчлэн их жимс өгсөн эсэхийг үзэцгээе гэв.

20 Мөнхүү улиран тохиох дор тэд явж эзэн уг модны унаган мөчрүүдийг нуусан тийш очиж мөн тэрээр зарцдаа: Эдгээрийг болгоогтун гэв; мөн тэр эхлээд “анхных нь их үр жимс өгснийг үзэв; мөн түүнчлэн энэ нь сайн байсныг үзэв. Мөн тэрээр зарцад: Үүний жимсийг түү, мөн үүнийг би өөртөө хадгалахын тулд улиралд нь зориулан нөөцөл гэв; учир нь болгоогтун, тэрээр хэлрүүн, энэ удаан хугацаанд би үүнийг арчилсан, мөн энэ нь их үр жимс өглөө гэв.

21 Мөнхүү улиран тохиох дор зарц эзэндээ: Та энэ модыг, өөрөөр хэлбэл уг модны энэ мөчрийг тарихаар энд яахан ирсэн билээ? Учир нь

болгоогтун, энэ нь таны талбайн бүх газраас хамгийн шимгүй хэсэг нь байсан хэмээв.

22 Мөн талбайн Эзэн түүнд, надад битгий зөвлө; энэ нь газрын шимгүй нь байсныг би мэдэж байсан; иймийн тул, би чамд хэлсэн, би үүнийг ийм удаан хугацаанд арчилсан, мөн чи энэ нь их үр жимс өгснийг харж байна шүү дээ хэмээв.

23 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцдаа: Нааш харагтун; би түүнчлэн уг модны өөр нэгэн мөчрийг тарьсныг үз; мөн газрын энэ хэсэг нь эхнийхээс илүү шимгүй байсныг чи мэднэ. Гэвч, модыг үзэгтүн. Би үүнийг ийм удаан хугацаанд арчилсан, мөн энэ нь их үр жимс өглөө; тиймийн тул, үүнийг хурааж мөн би үүнийг өөртөө хадгалж болохын тулд улиралд нь нөөцөл хэмээв.

24 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцдаа дахин хэлэв: Нааш харагтун, мөн түүнчлэн миний тарьсан, өөр нэгэн “мөчрийг үзэгтүн; би үүнийг түүнчлэн арчилсныг, мөн энэ нь үр жимс гаргасныг үзэгтүн.

25 Мөн тэрээр зарцад: Нааш харагтун мөн эцсийнхийг нь үзэгтүн. Болгоогтун, үүнийг би “газрын сайн хэсэгт тарьсан; мөн би үүнийг энэ урт хугацаанд арчилсан, мөн уг модны зөвхөн хэсэг нь л таримал жимс өгч мөн уг модны

⁶бусад хэсэг нь зэрлэг жимс өгчээ; болгоогтун, би энэ модыг бусдын адил арчилсан хэмээв.

26 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцад: сайн “жимс өгөөгүй мөчрүүдийг тайрагтун, мөн тэднийг галд хаягтун хэмээв.

27 Гэвч болгоогтун, зарц түүнд хэлэв: Энэ нь танд сайн үр жимс өгч, та үүнийг улиралд нь зориулан нөөцөлж магадгүй учир үүнийг тайрч, мөн орчныг нь сийрүүлж, мөн үүнийг бага зэрэг дахин арчилцгаая.

28 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн, мөн талбайн Эзэний зарц талбайн бүх жимсийг арчилсан бөлгөө.

29 Мөнхүү улиран тохиох дор урт хугацаа улиран одов, мөн талбайн Эзэн “зарцдаа: Ирэгтүн, бид талбайд дахин хөдөлмөрлөж болохын тулд талбай уруу очигцооё. Учир нь болгоогтун, ⁶цаг нь ойртож, мөн ⁶төгсгөл удахгүй ирнэ, иймийн тул, би өөртөө зориулж улирлынх нь тулд жимс нөөцлөх ёстой хэмээв.

30 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн мөн зарц талбайд уруудан ирэв; мөн тэд унаган мөчрүүд нь хугалагдсан мөн зэрлэг мөчрүүд залгагдсан тэрхүү модонд ирэв; мөн болгоогтун, бүх “төрлийн жимс уг модыг бөхийлгөсөн байв.

31 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн жимснээс амсаж үзэв, төрөл бүрийнх нь тоогоор болой. Мөн талбайн Эзэн хэлэв: Болгоогтун, энэ урт хугацаанд энэ модыг бид арчилсан, мөн би өөртөө улиралд нь зориулан их жимс нөөцөлсөн болой хэмээв.

32 Гэвч болгоогтун, энэ удаа энэ нь их жимс өгсөн байв, мөн тэнд “нэгээхэн ч сайн нь үгүй бөлгөө. Мөн болгоогтун, муу жимсний бүх төрлүүд байв; бидний бүх хөдөлмөрөөс үл хамааран, мөн надад ямар ч ашгийг үл өгөв, мөн эдүгээ би энэ модыг алдах нь намайг гонсойлгож байна.

33 Мөн талбайн Эзэн зарцад: Би дахин үүний сайн үр жимсийг өөртөө авч болохын тулд, бид уг модонд юу хийх билээ? хэмээв.

34 Мөн зарц Эзэндээ: Болгоогтун, эдгээрийн үндсүүдийг арчлахын тулд та чидуны зэрлэг модны мөчрүүдийг залгасан учир, эдгээр нь амьд мөн эдгээр нь эрсдэггүй байна; иймийн тул эдгээр нь одоохондоо сайн хэвээр байгааг та болгоож байна хэмээв.

35 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцдаа: Энэ мод надад ямар ч ашиггүй, мөн энэ нь олиггүй муу жимс өгөх аваас мөн түүний

25б З Ниф. 10:12–13.

26а Мат. 7:15–20;

Алма 5:36;

С ба Г 97:7.

29а С ба Г 101:55; 103:21.

б су Эцсийн өдрүүд,

Хожмын өдрүүд.

в 2 Ниф. 30:10;

Иаков 6:2.

30а су Урвалт.

32а ИС—Т 1:19.

үндэс ч надад ашиггүй хэмээв.

36 Гэсэн хэдий ч, үндсүүд нь сайн гэдгийг би мэднэ, мөн өөрийнхөө зорилгын тулд би эдгээрийг хадгалсан бөлгөө; мөн эдний их хүчний учир тэдгээр нь өмнө нь зэрлэг мөчрүүдээс сайн үр жимс өгсөн бөлгөө.

37 Гэвч болгоогтун, зэрлэг мөчрүүд ургаж мөн түүний үндэснүүдийн “хэрээс хэтэрчээ; мөн зэрлэг мөчрүүд үндсээ давж гарсан учир энэ нь олиггүй муу жимс ихээр өгчээ; мөн энэ нь маш ихээр муу үр жимс авчирсны учир энэ нь үхэж эхэлснийг та болгоож буй; мөн бид үүнийг хадгалахаар үүний төлөө ямар нэгэн зүйл хийхгүй бол, энэ нь удахгүй боловсрол галд хаягдаж магадгүй болжээ.

38 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцдаа: Талбайн хамгийн алсын хэсгүүдэд уруудан очицгооё, мөн унаган мөчрүүд түүнчлэн олиггүй муу үр жимс өгсөн эсэхийг үзье хэмээв.

39 Мөнхүү улиран тохиох дор тэд талбайн хамгийн алсын хэсгүүдэд уруудан очицгоов. Мөнхүү улиран тохиох дор унаган мөчрүүд ч гэсэн түүнчлэн өмхөрсөн байхыг тэд харав; тийм ээ, “эхнийх мөн дараагийнх мөн түүнчлэн эцсийнх нь; мөн тэдгээр нь бүгд өмх болсон байв.

40 Мөн эцсийнх нь “зэрлэг жимс нь модны сайн үр авчирсан тэр хэсгийг, бүр уг мөчрийг өгөрч мөн үхмэл болтол нь давамгайлсан байлаа.

41 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн уйлж, мөн зарцдаа: “Талбайнхаа төлөө би өөр юу хийж чадах сан билээ? гэв.

42 Болгоогтун, талбайн эдгээрээс бусад бүх үр жимс, өмхөрч муудсаныг би мэдэв. Мөн эдүгээ сайн үр жимс нэгэнтээ өгсөн тэдгээр нь түүнчлэн өмхөрч муудсан ажээ; мөн эдүгээ миний талбайн бүх мод тас цавчаад галд хаяхаас өөрөөр юунд ч хэрэггүй болжээ.

43 Мөн би “газрын сайн хэсэгт тарьсан ч мөчир нь өмхөрч муудсан энэ эцсийнхийг тийм ээ, бүр миний талбайн газрын бусад бүх хэсгээс дээгүүрт сонгогдсон үүнийг үзэгтүн.

44 Мөн би энэ модыг оронд нь тарьж болохын тулд газрын энэ хэсэгт байсан “саад болох зүйлийг би түүнчлэн тайрч хаясныг чи харсан шүү дээ.

45 Мөн үүний нэг хэсэг нь сайн үр жимс өгч мөн нөгөө хэсэг нь зэрлэг үр жимс өгснийг чи харсан; мөн би үүний мөчрүүдийг тасдан авч мөн галд хаяагүйн учир, болгоогтун, тэд гээр нь сайн мөчрийг даван гарсан учир энэ нь хатсан ажгуу.

37a С ба Г 45:28–30.

39a Иаков 5:20, 23, 25.

40a Морм. 6:6–18.

41a 2 Ниф. 26:24.

43a 2 Ниф. 1:5.

44a Ифер 13:20–21.

46 Мөн эдүгээ, болгоогтун, бидний талбайд минь зориулсан тэр бүх арчилгаанаас үл хамааран үүний модод өмхөрсөн учир тэд сайн үр жимс өгөхгүй болжээ; мөн би эдгээрийг хадгалж, өөртөө зориулан улиралд нь үр жимсийг нь нөөцөлж болно гэж найдсан бөлгөө. Гэвч, болгоогтун, эдгээр нь зэрлэг чидуны модтой адил болж мөн эдгээрийг “тас цавчаад мөн галд хаяхаас өөрөөр тусгүй болжээ; мөн би эдгээрийг алдах болсон нь намайг гонсойлгож байна.

47 Гэвч талбайдаа би өөр юу хийж чадах байсан билээ? Би үүнийг арчлахгүйн тулд гараа амраасан гэж үү? Үгүй, би үүнийг арчилсан, мөн орчныг нь сийрүүлсэн, мөн би үүнийг тайрсан, бас би үүнийг бордсон; мөн бараг л бүх өдрийн турш би “гараа сунгаж байсан, мөн “төгсгөл ойртож байна. Тэгээд талбайнхаа бүх моддыг тас цавчиж, мөн эдгээрийг шатаагдахын тулд галд хаях нь, энэ нь намайг гонсойлгож байна. Миний талбайг хэрэгцээгүй болгох тэр нь хэн билээ?

48 Мөнхүү улиран тохиох дор зарц эзэндээ: Энэ нь таны талбайн сүрлэгээс бус уу— үүний мөчрүүд тэр сайн үндсүүдээ давсан бус уу? Мөн мөчрүүд нь үндсүүдээ давамгайлсны учир болгоогтун, тэд гээр нь үндэснүүдээс илүүтэй

хурдан ургаж, өөрсдөдөө хүч чадлыг авчээ гэв. Болгоогтун, би хэлнэ, энэ нь таны талбайн модод өмхөрч байгаагийн шалтгаан уу?

49 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцад хэлэв: Явж мөн талбайн модыг тас цавчицгаая, мөн тэдгээр нь талбайн минь хөрсийг хэрэгцээгүй болгохгүйн тулд тэдгээрийг галд хаяцгаая, учир нь би бүгдийг хийсэн шүү дээ. Би талбайнхаа төлөө өөр юу хийж чадах байсан билээ?

50 Гэвч, болгоогтун, зарц талбайн Эзэнд: Үүнийг дахин “бага зэрэг түдгэлзээч хэмээв.

51 Мөн Эзэн хэлэв: Гийм ээ, би дахин бага зэрэг хүлээе, учир нь талбайнхаа моддыг алдах нь намайг гонсойлгож байна.

52 Иймийн тул, талбайнхаа хамгийн алслагдсан хэсгүүдэд миний тарьсан эдгээрийн “мөчрүүдээс авцгаая, мөн эдгээрийг авчирсан тэр модондоо залгацгаая; мөн жимс нь хамгийн гашуун мөчрүүдийг модноос нь тайрч авъя, мөн тэдгээрийн оронд модны унаган мөчрүүдийг залгая.

53 Мөн үүнийг би уг модыг эрсдүүлэхгүй байж болохын тул хийх болно, магадгүй, би үүний үндсүүдийг өөрийнхөө зорилгын тулд өөртөө хадгалж болохын тулд буюу.

54 Мөн, болгоогтун, хүссэн

46a 3 Ниф. 27:11.
47a 2 Ниф. 28:32;
Иаков 6:4.

б су Дэлхий—
Дэлхийн төгсгөл.
50a Иаков 5:27.

52a су Израил—
Израилын
цугларалт.

газартаа тарьсан тэр модны унаган мөчрүүдийн үндсүүд одоохондоо амьд байгаа; иймийн тул, тэдгээрийг би түүнчлэн миний өөрийнхөө зорилгын төлөө хадгалж болохын тулд, би энэ модны мөчрүүдийг тайрч мөн эднийг тэдгээрт “залгах болно. Тийм ээ, тэдгээр нь хангалттай хүчтэй болохоороо надад сайн жимс өгч магадгүйн тул, мөн би талбайнхаа үр жимсэнд сүр жавхлантай байхын тулд, би түүнчлэн өөртөө уг үндсүүдийг ч хадгалж болохын тулд би тэдгээрт өөрсдийнх нь эх модны мөчрүүдийг залгах болно.

55 Мөнхүү улиран тохиох дор зэрлэг болсон унаган модноос тэд авч мөн түүнчлэн зэрлэг болсон унаган моднуудад залгав.

56 Мөн тэд түүнчлэн зэрлэг болсон унаган моддоос авч мөн тэдгээрийн эх модонд нь залгасан ажээ.

57 Мөн талбайн Эээн зарцдаа: Уг модноос тэдгээр нь хамгийн гашуун биш аваас зэрлэг мөчрүүдийг бүү тайр; мөн миний хэлсний дагуу чи тэдгээрт залгах болно хэмээв.

58 Мөн бид талбайн моддыг дахин арчлах болно, мөн бид үүний мөчрүүдийг тайрах болно; мөн үхэх ёстой, өгөрсөн мөчрүүдийг уг моднуудаас бид таслан авч, мөн тэдгээрийг галд хаях болно.

59 Мөн түүний үндсүүд сайныхаа учир хүчийг авч магадгүйн учир би үүнийг хийх болно; мөн мөчрүүдийг сольсны учир сайн нь муугаа давамгайлж магадгүйн тулд буюу.

60 Мөн би унаган мөчрүүд мөн тэдгээрийн үндсүүдийг хадгалсан учир, мөн би унаган мөчрүүдийг тэдний эх модонд дахин залгасан учир, мөн талбайнхаа уг модод дахин сайн “үр жимс авчирч магад хэмээх тул эх модных нь үндсүүдийг хадгалж үлдээв; мөн би талбайнхаа үр жимсэнд дахин баясаж болохын тулд би анхны үр жимсний үндсүүдийг мөн мөчрүүдийг хадгалсандаа үлэмж баясаж болохын тулд буюу —

61 Иймийн тул, би унаган үр жимсийг, сайн мөн бусад бүх жимснээс хамгийн эрхэм унаган үр жимсийг авчирч болох замыг бэлтгэж болно хэмээн бид талбайд өөрсдийн хүчээр шаргуу “хөдөлмөрлөж болохын тулд очиж “зарц нарыг дуудагтун.

62 Иймийн тул, энэхүү эцсийн удаа бид очиж мөн чадлаараа хөдөлмөрлөцгөөе, учир нь болгоогтун, төгсгөл ойртож буй, мөн энэ нь би талбайгаа засаж тайрах эцсийн удаа болой.

63 Мөчрүүдийг залгагтун; тэд эхнийх байж, мөн эхнийх нь “эцсийнх байж болохын тулд эцсийнх дээр нь

54a 1 Ниф. 15:12–16.

60a Иса. 27:6.

61a С ба Г 39:11, 13, 17.

б Иаков 6:2;

С ба Г 24:19.

63a 1 Ниф. 13:42;

Ифер 13:10–12.

эхлэгтүн, мөн моддын эргэн тойрныг хөгшин болон залуу, эхний болон эцсийнх аль алиныг нь сийрэгжүүл; мөн эцсийнх болон эхнийх нь дахин нэгэнтээ эцсийн удаа арчлагдаж болохын тулд буюу.

64 Иймийн тул, тэдгээрийн орчныг сийрүүл, мөн тэдгээрийг тайрч зас, мөн тэдгээрийг дахин нэгэнтээ эцсийн удаа борд, учир нь төгсгөл ойртож буй. Мөн хэрэв эдгээр эцсийн залгалтууд ургаж мөн унаган үр жимс өгөх аваас, тэдгээр нь ургаж болохын тулд та нар тэдгээрт замыг бэлтгэх болно.

65 Мөн тэдгээр нь ургаж эхлэхээр сайны хүч мөн үүний хэмжээний дагуу та нар гашуун үр жимс өгөх мөчрүүдийг цэвэрлэн зайлуулах болно; мөн үүний үндсүүд залгагдсандаа дэндүү хүчирхэг болж, мөн тэдгээрийг мөхөөж, мөн би талбайнхаа моддыг алдах болуузай хэмээн та нар үүний мууг бүгдийг нэгмөсөн “цэвэрлэн зайлуулахгүй.

66 Учир нь талбайнхаа моддыг алдах нь намайг гонсойлгож байна; иймийн тул, үндэс болон дээд хэсэг нь адил хүчтэй байхын тулд та нар сайныг ургуулахын хамтаар сайн нь муугаа давамгайлж мөн тэд талбайн минь хөрсийг хэрэгцээгүй болгохгүйн тул муу нь тас

цавчигдан мөн галд хаягдах болтол буюу мууг зайлуулан цэвэрлэх болно; мөн тийн би мууг талбайгаасаа гарган шүүрдэж зайлуулах болно.

67 Мөн би унаган модны мөчрүүдийг дахин унаган модонд нь залгах болно;

68 Мөн унаган модны мөчрүүдийг би дахин модны унаган мөчрүүдэд нь залгах болно; мөн тийн тэд унаган үр жимс өгөхийн тулд би тэдгээрийг дахин хамтагтаж, мөн тэдгээр нь нэг байх болно.

69 Мөн муу нь, тийм ээ, бүр миний талбайн бүх нутаг дэвсгэрээс “зайлуулагдах болно; учир нь болгоогтун, зөвхөн энэ нэг л удаа би талбайгаа тайрч засах болно.

70 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн “зарцаа илгээв; мөн зарц явж мөн Эзэн түүнд зарлигласанчлангаар үйлдэв, мөн бусад зарц нарыг авчрав; мөн тэд ^бцөөн байлаа.

71 Мөн талбайн Эзэн тэдэнд: Яв, мөн өөрсдийн хүчээр талбайд ^ахөдөлмөрлө. Учир нь болгоогтун, энэ бол би талбайгаа ^бэцсийн удаа арчлах болно; учир нь төгсгөл ойрхон байна, мөн улирал нь хурдан ирэх бөлгөө; мөн хэрэв та нар өөрсдийн хүчээр надтай хамт хөдөлмөрлөх бөгөөс удахгүй ирэх тэр цагт зориулж би өөртөө нөөцлөх жимсэнд та нар ^абаясах болно гэв.

65a С ба Г 86:6–7.

69a 1 Ниф. 22:15–17, 23;

2 Ниф. 30:9–10.

70a С ба Г 101:55; 103:21.

б 1 Ниф. 14:12.

71a Мат. 21:28;

Иаков 6:2–3;

С ба Г 33:3–4.

б С ба Г 39:17; 43:28–30.

в С ба Г 18:10–16.

72 Мөнхүү улиран тохиох дор зарц нар явж мөн хүч чадлаараа хөдөлмөрлөв; мөн талбайн Эзэн тэдэнтэй түүнчлэн хөдөлмөрлөжээ; мөн тэд талбайн Эзэний зарлигуудыг бүх зүйлд дуулгавартай дагасан болой.

73 Мөн талбайд дахин унаган жимс нь бий болж эхлэв; мөн унаган мөчрүүд нь ургаж бас үлэмж өтгөрч эхлэв; мөн зэрлэг мөчрүүд тайрагдаж басхүү зайлуулагдаж эхлэв; мөн тэд үндэс болон үүний дээд хэсгийг хүчнийх нь дагуу адил тэгш байлгасан бөлгөө.

74 Мөн тэд ийн бүхий л идэвхээрээ, талбайн Эзэний зарлигуудын дагуу, бүр муу нь талбайгаас зайлуулагдтал хөдөлмөрлөв, мөн Эзэн моддын дахин өгч эхэлсэн унаган жимсийг өөртөө хадгалсан болой; мөн тэдгээр нь “нэгэн биеийн адил болов; мөн үр жимс нь адил тэгш болов; мөн талбайн Эзэн түүнд эхлэлээс аваад хамгаас үлэмж эрхэм байсан унаган жимсийг өөртөө хадгалсан бөлгөө.

75 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн өөрийнх нь жимс сайн байсныг харж мөн түүний талбай дахин муудаагүй байгааг харж тэрээр зарц нараа дуудаж мөн тэдэнд хэлэв: Болгоогтун, учир нь энэ эцсийн удаа бид талбайг минь арчилсан билээ; мөн

би тааллынхаа дагуу үйлдсэнийг та нар харлаа; мөн би бүр унаган жимсийг хадгалсан тул тэр нь сайн байна, бүр эхлэлд байсны адил бөлгөө. Мөн та нар “адислагдсан болой; учир нь та нар надтай хамт миний талбайд шаргуугаар хөдөлмөрлөж байлаа, мөн миний зарлигуудыг дагасан, мөн талбай минь дахин муудаагүйн учир, надад “унаган жимсийг дахин авчирлаа, мөн муу нь зайлуулагдсан, болгоогтун та нар надтай хамт талбайн минь үр жимсний учир баясах болно.

76 Учир нь болгоогтун, хурдан ирэх тэр улиралд зориулж би өөртөө талбайнхаа жимсийг “удаан хугацаанд нөөцлөх болно; мөн би талбайгаа эцсийн удаа арчилсан мөн үүнийг тайрч зассан, мөн орчныг нь сийрэгжүүлсэн, мөн үүнийг бордсон билээ; иймийн тул, би ярьсныхаа дагуу, удаан хугацаагаар уг жимснээс өөртөө нөөцлөх болно.

77 Мөн олиггүй жимс талбайд минь дахин ирэх цаг болоход би сайныг бас мууг нь цуглуулах болно; мөн сайныг нь би өөртөө хадгалах болно, мөн мууг нь би үүнийг өөрийнх нь байранд нь зайлуулах болно. Мөн тэгээд “улирал бас төгсгөл ирнэ; мөн талбайгаа би галд “шаагагдахаар болгоно.

74a С ба Г 38:27.

75a 1 Ниф. 13:37.

б су Израил.

76a 1 Ниф. 22:24–26.

су Мянган жил.

77a Илч. 20:2–10;

С ба Г 29:22–24;

43:29–33; 88:110–116.

б су Дэлхий—

Дэлхийн төгсгөл.

БҮЛЭГ 6

Их Эзэн эцсийн өдрүүдэд Израилыг буцаан авчрах болно — Дэлхий галаар шатаагдах болно — Хүмүүн галан болон хүхэрт чулууны нуураас зайлсхийхийн тулд Христийг дагах ёстой. Ойролцоогоор мээ 544–421 он.

Мөн эдүгээ, болгоогтун, ах дүү нар минь, би та нарт бошиглоно хэмээн хэлсэнчлэн, болгоогтун, энэ бол миний бошиглол—тэрбээр тэднийг таримал чидуны модтой адилтгасан, Израилын угсааны талаарх, бошиглогч “Зиносын ярьсан зүйлүүд нь, гарцаагүй улиран тохиох ёстой.

2 Мөн тэрбээр хүмүүсээ хоёр дахь удаагаа “нэгтгэхээр мутраа дахин хөдөлгөх тэр өдөр, тийм ээ, бүр эцсийн удаа, Их Эзэний “үйлчлэгчид түүний “хүчээр ‘талбайг нь ‘арчилж мөн тайрч засахаар урагш одох тэр өдөр; мөн үүний дараа “төгсгөл удахгүй ирнэ.

3 Мөн түүний талбайд шаргуугаар хөдөлмөрлөсөн тэд хичнээн ихээр адислагдсан билээ; мөн өөрсдийн байранд зайлуулагдах тэд хичнээн ихээр зүхэгдсэн билээ! Мөн дэлхий галаар “шатаагдах болно.

4 Мөн Бурхан минь бидэнд хичнээн нигүүлсэнгүй билээ, учир нь тэрбээр “Израилын угсааны үндсүүдийг мөн мөчрүүдийг аль алиныг нь санадаг бөлгөө; мөн тэрбээр бүхэл өдрийн турш тэдэнд “мутраа урагш сунгадаг; мөн тэд “зөрүүд бас эсэргүүцэгч хүмүүс; гэвч зүрхээ хатууруулахгүй тэд Бурханы хаант улсад аврагдах болно.

5 Иймийн тул, хайрт ах дүү нар минь, та нарыг чанд үгсээр наманчлаасай хэмээн, мөн зүрх сэтгэлийн дүүрэн зорилготойгоор ирж, мөн тэрбээр та нарт үнэнчийн адил Бурханд “үнэнч байхыг би гуйна. Мөн түүний нигүүлслийн “мутар та нарын зүг өдрийн гэрэлд сунгагдсан байхад, зүрх сэтгэлээ бүү хатууруулаач.

6 Тийм ээ, өнөөдөр, хэрэв та нар түүний дууг сонсьё гэвэл зүрх сэтгэлээ бүү хатууруулаач; учир нь та нар яагаад “үхэх ёстой билээ?

7 Учир нь болгоогтун, та нар Бурханы сайн үгээр бүхэл өдрийн турш арчлагдсаны дараа, та нар “тас цавчигдан мөн галд хаягдах ёстойн улмаас та нар олиггүй үр жим гарган авчрах бус уу?

8 Болгоогтун, та нар эдгээр үгсийг хүлээн авахгүй гэж үү?

6 1а Иаков 5:1.

2а 1 Ниф. 22:10–12;

С ба Г 110:11.

су Сайн Мэдээний сэргээлт.

б Иаков 5:6:1.

в 1 Ниф. 14:14.

г су Их Эзэний

талбай.

д Иаков 5:7:1.

е 2 Ниф. 30:10.

3а 2 Ниф. 27:2;

Иаков 5:77;

3 Ниф. 25:1.

4а 2 Сам. 7:24.

б Иаков 5:47.

в Мозая 13:29.

5а су Эв нэгдэл.

б Алма 5:33–34;

3 Ниф. 9:14.

6а Езек. 18:21–23.

7а Алма 5:51–52;

3 Ниф. 27:11–12.

Та нар бошиглогчдын үгсийг эсэргүүцдэг; мөн түүний талаар ийм олон нь ярьсны дараа, Христийн талаар яригдсан үгсийг бүгдийг та нар эсэргүүцэх гэж үү; мөн Христийн сайн үгийг, мөн Бурханы хүчийг, мөн Ариун Сүнсний “бэлгийг үгүйсгэж, мөн Ариун Сүнснийг зайлуулан, мөн та нарын төлөө үүсгэгдсэн, гэтэлгэлийн агуу төлөвлөгөөгөөр элэг доог хийх гэж үү?

9 Та нар хэрэв эдгээр зүйлийг үйлдвээс, Христ дэх гэтэлгэлийн мөн амилуулалтын хүч, та нарыг Бурханы “тавцангийн өмнө аймшигт” гэмтэйгээр болон ичгүүртэйгээр зогсоохоор авчрах болно гэдгийг та нар эс мэдэх гэж үү?

10 Мөн “шударга ёсны хүчний дагуу, учир нь шударга ёс үгүйсгэгдэж чадахгүй, та нар “галт ба хүхэрт нууранд очих ёстой, дел нь унтраагдашгүй тэр, мөн утаа нь үеийн үед бас үүрд уугих тэр, галт болон хүхэрт нуур нь “төгсгөлгүй” зовлон бөлгөө.

11 Ай тэгээд, хайрт ах дүү нар минь, наманчлагтун та нар, мөн “давчуу хаалгаар орогтун, мөн нарийн замаар, мөнх амьдралыг олох хүртлээ үргэлжлүүлэн явагтун.

12 Ай “мэргэн байгтун; би өөр юу хэлж чадахсан билээ?

13 Эцэст нь, Бурханы таалалт тавцан, ёс бус тэдний “аймаар айдас мөн аюумшгаар цохих тэрхүү тавцангийн өмнө би та нартай уулзах хүртэл, та нарт сайныг хүсье. Амен.

БҮЛЭГ 7

Шерим Христийг үгүйсгэн, Иаковтай маргаж, тэмдэг шаардан, мөн Бурханаар цохигдов— Бүх бошиглогчид Христийн мөн түүний цагаатгалын тухай ярьдаг— Нифайчууд өөрсдийн бүх өдрүүдийн турш бэдрэгсдийн амьдралаар амьдарч, зовлон зүдгүүрт төрөөд мөн леменчүүдээр үзэн ядагдав. Ойролцоогоор мээ 544–421 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор хэдэн жил улиран одсоны дараа, Нифайн хүмүүсийн дунд Шерим хэмээн нэрлэгдсэн нэгэн хүн ирэв.

2 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүмүүсийн дунд номлож, мөн Христ байхгүй хэмээн тунхаглаж эхлэв. Мөн тэрээр хүмүүсийг зусардсан олон зүйл номлосон ажгуу; мөн Христийн сургаалыг устгаж болохын тулд тэр үүнийг хийсэн ажээ.

3 Мөн тэрээр хүмүүсийн зүрх сэтгэлийг зайцуулан дагуулж болохын тулд тэрээр шаргуу хөдөлмөрлөсөн, үүнийхээ хэрээр тэр олон

8a су Ариун Сүнсний бэлэг.

9a су Эцсийн шүүлт.

б Мозай 15:26.

су Гэм.

10a су Шударга ёс.

б 2 Ниф. 28:23.

су Там.

в С ба Г 19:10–12.

г су Ял.

11a 2 Ниф. 9:41.

12a Морм. 9:28.

13a Алма 40:14.

зүрх сэтгэлийг зайцуулсан ажээ; мөн би, Иаков, ирэх ёстой Христэд итгэлтэй гэдгийг мэдсэний учир, тэрээр над дээр ирэх боломжийг ихэд эрэлхийлж байв.

4 Мөн тэрээр эрдэмт нэгэн учир хүмүүний хэл ярианы төгс мэдлэгийг эзэмшсэн байв; иймийн тул, чөтгөрийн хүчний дагуу тэр ихээхэн зусардалтыг, мөн ярих ихээхэн хүчийг хэрэглэж чадсан ажгуу.

5 Мөн эдгээр зүйлүүдийн талаар миний үзсэн олон зүйл мөн олон “илчлэлт байсан хэдий ч, тэрээр миний итгэлийг гуйвуулахаар найдаж байв; учир нь би үнэхээр тэнгэр элчүүдийг харж, мөн тэд надад тохинуулсан билээ. Мөн түүнчлэн, надад чухам тэр үгийг ярьсан Их Эзэний дуу хоолойг цагаас цагт би сонссон; иймийн тул, би гуйвуулагдаж чадахгүй бөлгөө.

6 Мөнхүү улиран тохиох дор тэрээр надад ирж, мөн ийм янзаар тэрээр надад ярьж, хэлсэн нь: Иаков ах аа, би тантай ярих боломжийг ихэд эрэлхийлэв; учир нь та сайн мэдээ, эсвэл Христийн сургаал гэж нэрлэх тэрнийг номлон, ихэд явдгийг тань би сонссон мөн түүнчлэн мэднэ.

7 Мөн энэ хүмүүсийн олныг нь та зайцуулсан учир тэд Бурханы зөв замыг гажуудуулсан,

мөн зөв зам болох Мосегийн хуулийг “эс дагадаг; мөн Мосегийн хуулийг таны хэлдгээр одоогоос олон зуун жилийн хойно ирэх тэр хүнийг бишрэн шүтэхэд зориулан өөрчилдөг. Мөн эдүгээ болгоогтун, би, Шерим, энэ бол Бурханыг доромжилсон хэрэг гэдгийг танд мэдэгдэж байна; учир нь нэг ч хүн ийм зүйлийг эс мэднэ; учир нь болох зүйлийг тэр “хэлж эс чадна. Мөн иймэрхүү маягаар Шерим миний эсрэг маргав.

8 Гэвч болгоогтун, Их Эзэн Бурхан өөрийн “Сүнсийг миний бодгальд юулж, үүний хэрээр би түүний бүх үгсийнх нь тул түүнийг ичгүүрлэсэн бөлгөө.

9 Мөн би түүнд хэлэв: Та ирэх Христийг үгүйсгэнэ үү? Мөн тэр хэлэв: Хэрэв Христ гэж байх аваас, би түүнийг үгүйсгэх нь үгүй; гэвч Христ байхгүйг гэдгийг би мэднэ, мөн байсан нь ч үгүй, бас хэзээ ч байх нь үгүй.

10 Мөн би түүнд: Судруудад та итгэдэг үү? гэв. Мөн тэр, Тийм гэв.

11 Мөн би түүнд хэлэв: Тэгвэл та тэдгээрийг ойлгодоггүй юм байна; учир нь тэдгээр нь үнэхээр Христийг гэрчилдэг. Болгоогтун, нэгээхэн ч бошиглогч тэдгээр нь энэхүү Христийн талаар л өгүүлснээс биш, юуг ч “бошиглосон

7 аа 2 Ниф. 11:3;

Иаков 2:11.

7а Иаков 4:5.

б Алма 30:13.

8а су Сүнсний

удирдамж,
Сүнслэгээр
нөлөөлөгдөх.

11а Илч. 19:10;

1 Ниф. 10:5;

Иаков 4:4;

Мозая 13:33–35;

С ба Г 20:26.

су Есүс Христ.

нь мөн бичсэн нь үгүйг би танд хэлнэ.

12 Мөн үүгээр ч зогсохгүй—энэ нь надад үзүүлэгдсэн, учир нь би сонсож бас үзсэн; мөн энэ нь түүнчлэн надад Ариун Сүнсний “хүчээр үзүүлэгдсэн болой; иймийн тул, хэрэв цагаатгал үйлдэгдээгүй аваас бүх хүн төрөлхтөн ⁶төөрөлдөх ёстойг би мэднэ.

13 Мөнхүү улиран тохиох дор тэрээр надад хэлэв: Та тэгж сайн мэдэх түүгээр, Ариун Сүнсний хүчээр надад “тэмдэг үзүүлээч.

14 Мөн би түүнд хэлэв: “Үнэн гэдгийг нь таны мэдэх зүйлд танд тэмдэг үзүүлэхийн тулд Бурханыг сонжих би хэн билээ? Гэсэн ч та үүнийг үгүйсгэдэг, яагаад гэвэл та ⁶чөтгөрийнх учраас тэр. Гэсэн хэдий ч, миний хүсэл гүйцэлдэх нь үгүй; харин хэрэв Бурхан таныг цохивол, тэр нь тэнгэрт мөн газарт хүчтэй түүний танд үзүүлэх тэмдэг болог; мөн түүнчлэн, тэр нь Христ ирэх болно гэсний тэмдэг буюу. Мөн, гүйцэлдсэн байг, минийх бус харин таны таалал Ай Их Эзэн минь.

15 Мөнхүү улиран тохиох дор би, Иаков, эдгээр үгсийг ярьсны дараа, Их Эзэний хүч түүн дээр ирж, тэгээд тэр газарт унав. Мөнхүү улиран

тохиох дор тэр олон өдрийн турш сувилуулсан бөлгөө.

16 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр хүмүүст: Маргааш нэгдэн цугларцгаа, учир нь би үхэх болно; иймийн тул, би үхэхээсээ өмнө хүмүүст ярихыг хүсч байна хэмээв.

17 Мөнхүү улиран тохиох дор маргааш нь олон хүн нэгдэн цугларсан байв; мөн тэрээр тэдэнд тодорхойгоор ярьж мөн тэдэнд өөрийн заасан зүйлүүдээ үгүйсгэв, мөн Христийг, мөн Ариун Сүнсний хүчийг, мөн тэнгэр элчүүдийн тохинууллыг хүлээн зөвшөөрөв.

18 Мөн тэрээр “чөтгөрийн хүчээр ⁶мэхлэгдсэн байснаа тэдэнд тодорхой ярив. Мөн тамын тухай, мөн үүрд мөнхийн тухай, мөн мөнхийн цээрлэлийн тухай тэрээр ярьсан бөлгөө.

19 Мөн тэрээр хэлэв: би Бурханд худал хэлсний учир, “уучлагдашгүй нүгэл үйлдлээ хэмээн айж байна би; учир нь би Христийг үгүйсгэж, мөн би судруудад итгэсэн хэмээн хэлсэн билээ; мөн тэдгээр нь үнэхээр түүнийг гэрчилдэг. Мөн би тийн Бурханд худлаа хэлсэн учир миний байдал ⁶аймшигтай байх болно хэмээн маш ихээр айж байна би; гэвч би Бурханд нүглээ хүлээсэн билээ.

12a су Бурхан, Бурхан тэргүүтэн — Бурхан Ариун Сүнс; Ариун Сүнс. б 2 Ниф. 2:21.
13a Мат. 16:1–4;

Алма 30:43–60.
су Тэмдэг.
14a Алма 30:41–42.
б Алма 30:53.
18a су Четгөр.
б Алма 30:53.

су Заль, Залилах, Залилан.
19a су Уучлагдашгүй нүгэл.
б Мозая 15:26.

20 Мөнхүү улиран тохиох дор тэр тэдгээр үгсийг хэлээд тэрээр өөр юу ч хэлж чадсангүй, мөн түүний “сүнс зайллаа.

21 Мөн олон түмэн тэрээр бараг сүнс нь зайлж байхдаа эдгээр зүйлийг гэрчлэх болсонд, тэд үлэмж ихээр гайхан цочирдсон байв; үүний хэрээр Бурханы хүч тэдэн дээр доошлон ирж, мөн тэд газарт унатлаа тэгж “давамгайлагдсан бөлгөө.

22 Эдүгээ, энэ нь Иаков надад тааламжтай байв, учир нь тэнгэр дэх Эцэгээсээ би үүнийг хүссэн юм; учир нь тэрээр миний гуйлтыг сонсож мөн миний залбиралд хариулсан бөлгөө.

23 Мөнхүү улиран тохиох дор Бурханы амар амгалан болон хайр хүмүүсийн дунд дахин сэргээгдсэн байв; мөн тэд судруудыг “судалж, мөн ёс бус энэ хүний үгсийг дахин сонссонгүй.

24 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийг үнэний мэдлэгт дахин оруулах хийгээд “сэргээхийн тулд олон арга эдэгдсэн байлаа; гэвч энэ бүгд ⁶талаар өнгөрөв, учир нь тэд ⁶дайнүүд болон ⁷цусанд баясдаг байв, мөн өөрсдийнх нь ах дүүс болох бидний эсрэг мөнхийн ⁸үзэн ядалтыг агуулдаг байв. Мөн тэд зэвсгийнхээ хүчээр

биднийг устгахыг үргэлж эрэлхийлж байв.

25 Иймийн тул, Нифайн хүмүүс өөрсдийн авралын Бурханд болон “хаданд итгэж, мөн өөрсдийн зэр зэвсэг, мөн өөрсдийн бүх хүч чадлаар тэдний эсрэг бэхлэн хамгаалсан билээ; иймийн тул, тэд одоохондоо дайснуудаа ялан дийлэгсэд болсон бөлгөө.

26 Мөнхүү улиран тохиох дор би, Иаков, өтөлж эхлэв; мөн энэ хүмүүсийн цэдэг Нифайн “бусад ялтсууд дээр хадгалагдсан буй, иймийн тул, мэдлэгээ шавхсаны дагуу бичиглэснээ тунхаглав, би цаг хугацаа бидэнтэй хамт улиран одож, мөн түүнчлэн бидний ⁶амьдрал зүүдэнд байсан мэт улиран одож байна; учир нь бид ганцаардсан мөн чанд хүмүүс, бэдрэгсэд, Иерусалимаас хөөгдсөн, аглаг буйдад зовлон дунд төрсөн, түүнчлэн ах дүүсээрээ үзэн ядагдахын хэрээр дайн тэмцлийг өдөөгч болжээ хэмээн хэлснээр би энэхүү цэдгийг дуусгая; иймийн тул, бид өөрсдийн өдрүүдэд гашуудсаар байлаа.

27 Мөн би, Иаков, булшиндаа удахгүй доош орох ёстойгоо ойлгов; иймийн тул, би хүү “Иностоо хэлэв: Эдгээр ялтсуудыг авагтун. Мөн миний ах Нифайн надад ⁶зарлигласан зүйлийг би

20а Иер. 28:15–17.

21а Алма 19:6.

23а Алма 17:2.

24а Инос 1:20.

б Инос 1:14.

в Мозая 10:11–18.

г Жером 1:6;

Алма 26:23–25.

д 2 Ниф. 5:1–3;

Мозая 28:2.

25а су Хад.

26а 1 Ниф. 19:1–6;

Жером 1:14–15.

су Ялтсууд.

б Иаков 4:14.

27а Инос 1:1.

б Иаков 1:1–4.

түүнд хэлсэн, мөн зарлигуудад дуулгавартай байхаа тэрээр амласан бөлгөө. Мөн би багахныг бичиглэсэн буй эдгээр ялтсууд дээрх бичиглэлээ төгсгөл болгоё; мөн

уншигчид би сайн сайхныг хүсч, ах дүүсийн маань олон нь миний үгсийг унших болов уу гэж найдъя, Ах дүүс минь, Бурхан та нартай хамт байг.

Иносын Ном

Инос хүчтэйгээр залбирч мөн нүглээсээ ангижрах болов—Их Эзэний дуу хоолой, түүний оюун ухаанд ирж леменчүүдэд ирээдүйн өдөр авралыг амлав—Нифайчууд леменчүүдийг сэргээхийг эрэлхийлэв—Инос өөрийн Гэтэлгэгчид баясав. Ойролцоогоор мэв 420 он.

БОЛГООГТУН, мөнхүү ули-
Бран тохиох дор би, “Инос, миний ⁶эцэг шударга хүн байсныг мэдэхийн учир— тэрээр надад өөрийн хэлээр, мөн түүнчлэн Их Эзэний ⁶халамж хийгээд зөвлөгөөнд ⁶заан хүмүүжүүлсэн болой— мөн үүний учир Бурханы минь нэр алдаршиг.

2 Мөн нүглийнхээ ангижралыг хүлээн авахаас өмнө, би Бурханы өмнө “хэрхэн өөртэйгөө ⁶тэмцэлдсэнээ танд би хэлэх болно.

3 Болгоогтун, би ан агнахаар ойд очив; мөн мөнх амьдрал, бас гэгээнтнүүдийн “баяслын

талаар эцгийнхээ ярьж байхыг олонтаа сонссон тэр үгс, зүрх сэтгэлд минь ⁶гүнзгий шингэсэн байв.

4 Мөн бодгаль минь “өлссөн байв; мөн намайг Бий Болгогчийн өмнө ⁶сөхөрсөн би, мөн хүчит ⁶залбирлаар мөн бодгалийнхаа төлөө гуйлтаар түүнээс гуйсан; мөн бүхэл өдрийн турш би түүнээс гуйв; тийм ээ, мөн шөнө ирэхэд би дуугаа өндөрсгөн үргэлжлүүлсээр байсан учир энэ нь тэнгэрт хүрсэн бөлгөө.

5 Мөн тэгтэл нэгэн “дуу хоолой надад ирж, өгүүлсэн нь: Инос нүглүүд чинь өршөөгдсөн, мөн чи адислагдах болно хэмээв.

6 Мөн би, Инос, Бурхан худал хэлж эс чадахыг мэднэ; иймийн тул, миний гэм зайлуулагдсан бөлгөө.

7 Мөн би хэлэв: Их Эзэн, энэ хэрхэн бүтэв?

8 Мөн тэрээр надад хэлэв: Чи урьд нь хэзээ ч сонсож бас

[инос]

1 1а су Инос, Иаковын хүү.

б 2 Ниф. 2:2–4.

в Ефес. 6:4.

г 1 Ниф. 1:1–2.

2а су Нүглүүдийн

ангижрал.

б Эхл. 32:24–32;

Алма 8:10.

су Наманчлах,

Наманчлал.

3а су Баяр баясгалан.

б 1 Ниф. 10:17–19;

Алма 36:17–21.

4а 2 Ниф. 9:51;

3 Ниф. 12:6.

б су Хүндэтгэл.

в су Залбирал.

5а су Илчлэлт.

хараагүй, Христэд “итгэлтэйн чинь учир буюу. Мөн тэрээр өөрийгөө бие махбодид үзүүлэхээс өмнө олон жил улирч одно; иймийн тул, яв, итгэл чинь чамайг ^бэдгээлээ.

9 Эдүгээ, улиран тохиох дор би эдгээр үгсийг сонсоод өөрийн ах дүү нар, нифайчуудын аз жаргалын төлөө “хүслийг мэдэрч эхэллээ; иймийн тул, би тэдний төлөө бүх сэтгэл оюунаа Бурханд ^бдэлгэсэн бөлгөө.

10 Мөн намайг тийн оюун бодолдоо зүдрэн байхад, болгоогтун, Их Эзэний дуу хоолой миний “ухаанд дахин ирж, өгүүлсэн нь: Зарлигуудыг минь дагах тэдний чармайлтын дагуу ах дүүст чинь би зочлох болно. Би тэдэнд энэ нутгийг ^бөгсөн билээ, мөн энэ нь ариун нутаг; мөн алдсын учир бус аваас би үүнийг “зүхэх нь үгүй; иймийн тул, би хэлснийхээ дагуу ах дүүст чинь зочлох болно; мөн тэдний зөрчлүүдийг өөрсдийнх нь толгой дээрх харууслын хамт би доош авчрах болно.

11 Мөн би, Инос, эдгээр үгсийг сонссоны дараа, Их Эзэнд итгэх итгэл минь гуйвшгүй болж эхлэв; мөн би өөрийн ахан дүүс, лемен-

чүүдийн төлөө удаан хугацаагаар олон зүдрэлтэйгээр түүнд залбирав.

12 Мөнхүү улиран тохиох дор би “залбирч мөн бүх хүчээрээ чармайн хөдөлмөрлөсний дараа, Их Эзэн надад: итгэлийн чинь учир, ^бхүслийн чинь дагуу би чамд өгнө хэмээв.

13 Мөн эдүгээ болгоогтун, түүнээс миний хүссэн тэрхүү хүсэл ийм байв — хэрэв миний хүмүүс, нифайчууд, зөрчилд унаж мөн ямар нэгэн байдлаар “устгагдах бол, мөн леменчүүд устгагдахгүй байх аваас Их Эзэн Бурхан нифайчууд болох миний хүмүүсийн цэдгийг ^б хадгалан үлдээх болгоосой хэмээнэ; бүр хэрэв түүний ариун мутрын хүчээр байсан ч, энэ нь хэзээ нэгэн ирээдүйн өдөр леменчүүдэд, тэд авралд “авчрагдаж болохын тулд ‘гаргагдаж болно хэмээсан буюу —

14 Учир нь одоо бол тэднийг үнэн итгэлд сэргээх гэсэн бидний зүтгэлүүд “талаар болсон ажгуу. Мөн хэрэв энэ нь боломжтой байсан бол, тэд бидний цэдгүүдийг мөн биднийг, мөн түүнчлэн бидний эцэг өвгөдийн бүх заншил уламжлалуудыг ^бустга-

8а Ифер 3:12–13.
су Итгэл.

б Мат. 9:22.

9а 1 Ниф. 8:12;

Алма 36:24.

б 2 Ниф. 33:3;

Мор. үгс 1:8;

Алма 34:26–27.

10а су Сүнсний
удирдамж,

Сүнслэгээр
нөлөөлөгдөх;
Оюун.

б 1 Ниф. 2:20.

в Ифер 2:7–12.

12а Морм. 5:21; 9:36.

б Дуул. 37:4;

1 Ниф. 7:12;

Хил. 10:5.

13а Морм. 6:1, 6.

б Мор. үгс 1:6–11;
Алма 37:2.

в Алма 37:19;

Ифер 12:22;

С ба Г 3:18.

г Алма 9:17.

14а Иаков 7:24.

б Морм. 6:6.

хаар тэд уурандаа ам алдсан бөлгөө.

15 Иймийн тул, Их Эзэн Бурхан бидний цэдгүүдийг “хадгалан үлдээх боломжтойг би мэдсэний учир, би түүнээс үргэлж гуйв, учир нь тэрээр надад: Чи Христийн нэрээр хүлээн авах болно хэмээн найдаж итгэлтэйгээр гуйсан юуг ч болов, чи хүлээн авах болно хэмээн хэлсэн болой.

16 Мөн надад итгэл байж, мөн би Бурханд тэрээр “цэдгүүдийг” хадгалан үлдээхийг гуйсан болой; мөн тэрээр тэдгээрийг зохих цагт нь леменчүүдэд “авчрах болно хэмээн надтай гэрээлсэн бөлгөө.

17 Мөн би, Инос, энэ нь түүний хийсэн тэрхүү гэрээний дагуу байхыг мэдсэн бөлгөө; иймийн тул, бодгаль минь амрав.

18 Мөн Их Эзэн надад хэлэв: Чиний эцэг өвгөд түүнчлэн энэ зүйлийг надаас хүссэн юм; мөн энэ нь тэдний итгэлийн дагуу гүйцэлдэх болно; учир нь тэдний итгэл чинийх лугаа адил байсан бөлгөө.

19 Мөнхүү улиран тохиох дор би, Инос, ирэх зүйлийг бошиглон, мөн өөрийн сонссон мөн үзсэн зүйлийг гэрчлэн Нифайн хүмүүсийн дунд одсон бөлгөө.

20 Мөн Нифайн хүмүүс леменчүүдийг Бурханы үнэн

итгэлд сэргээхээр чармайн эрэлхийлснийг би гэрчилж байна. Гэвч бидний “хөдөлмөр талаар өнгөрсөн билээ; тэдний үзэн ядалт нь хөдөлгөөнгүй бэхэжсэн юм, мөн тэд хилэнцэт байдалдаа удирдагдсан учир тэд зэрлэг, мөн догшин ширүүн, мөн “цусанд дуртай хүмүүс болж, “хиймэл шүтээн хийгээд бузар байдлаар дүүрсэн болой; агнасан амьтдаараа хооллон; майханд амьдарч, мөн хэвлийн тус газраараа богино арьс бүслэн мөн үсээ хусуулж аглаг буйдад хэрэн бэдрэх бөлгөө; мөн тэдний чадвар нь “нум суманд, мөн тахир сэлэм, мөн сүхэнд байлаа. Мөн тэдний олон нь түүхий махнаас өөр юуг ч эс иддэг; мөн тэд биднийг устгахаар үргэлж эрэлхийлдэг болой.

21 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүс газар боловсруулж, мөн бүх төрлийн будаа тариа, мөн жимс “ургуулж, мөн мал сүргийг, мөн янз бүрийн үхэр малыг төрөл төрлөөр нь, мөн ямаа, бас зэрлэг ямаа, мөн түүнчлэн олон адуу өсгөдөг болсон ажээ.

22 Мөн үлэмж олон “бошиглогч бидний дунд байв. Мөн хүмүүс нь “зөрүүд, ойлгохдоо хэцүү хүмүүс байв.

23 Мөн үлэмж “хэрцгийг авир, дайнууд мөн тэмцлүүд,

15a су Судрууд—
Хадгалагдсан
судрууд.

16a су Мормоны Ном.
б 3 Ниф. 5:13–15;
С ба Г 3:19–20;

10:46–50.
в 2 Ниф. 27:6.
20a Моро. 9:6.

б Жером 1:6.
в Мозая 9:12.
су Хиймэл шүтээн.

г Мозая 10:8.

21a Мозая 9:9.

22a Мор. үгс 1:16–18.

б Жером 1:3.

23a 1 Ниф. 16:2;

2 Ниф. 33:5.

мөн устгалуудын талаар ⁶номлож мөн бошиглохоос, мөн үхлийг, мөн мөнхийн хугацааг, мөн Бурханы хүч болон шийтгэлүүд, мөн эдгээр бүх зүйлийг үргэлж ⁶сануулахаас — тэднийг Их Эзэнээс эмээх айдаст байлгахын тулд үргэлж бусниулахаас бусдаар бол юу ч байсангүй. Тэднийг устгал уруу доош хурдан явахаас хамгаалах эдгээр зүйлүүдээс, мөн ярихдаа үлэмж агуу тодорхой байхаас өөр юу ч эс байсныг хэлнэ би. Мөн ийм маягаар тэдний талаар бичиглэх буюу би.

24 Мөн нифайчууд бас леменчүүдийн хоорондоо дайтахыг амьдралынхаа өдрүүдэд үзсэн болой би.

25 Мөнхүү улиран тохиох дор би өтөлж эхлэв, мөн бидний өвөг Лихай Иерусалимыг “орхисон тэр цагаас нэг зуун далан есөн жил улиран оджээ.

26 Мөн би удахгүй доош булшиндаа орох ёстойгоо мэдэв, мөн Бурханы хүч над дээр үйлдсэн учир би энэ хүмүүст номлож мөн бошиглон, мөн Христ дэх тэрхүү үнэний дагуу үгийг тунхаглах ёстой байв. Мөн би үүнийг бүх өдрүүдийнхээ турш тунхагласан мөн дэлхийнхээс илүүгээр үүнд баяссан бөлгөө.

27 Мөн би Гэтэлгэгчтэйгээ хамт байх тэрхүү “амрах газартаа удахгүй явна; учир нь би түүнд амрах болно гэдгээ мэднэ. Мөн ⁶зуурдын бие нь “үхэшгүйг өмсөх тэр өдөр баясна би, мөн түүний өмнө зогсох болно, тэгээд түүний царайг тааламжтайгаар харж, мөн тэрээр надад: Надад ирэгтүн, адислагдсан болой чи, миний Эцэгийн ‘харшуудад чамд зориулан бэлтгэгдсэн байр буй гэж хэлэх болно. Амен.

ЖЕРОМЫН НОМ

Нифайчууд Мосегийн хуулийг дагаж, Христийн ирэлтийг хүлээн, мөн уг нутагт дэгжив — Олон бошиглогч хүмүүсийг үнэний замд байлгахаар хөдөлмөрлөв. Ойролцоогоор мээ 399–361 он.

ЭДҮГЭЭ болгоогтун, би, Жером, эцэг Иносынхоо зарлигийн дагуу бидний “удмын бичиг хадгалагдаж болохын тулд хэдэн үг бичье.

2 Мөн “эдгээр ялтсууд ⁶жигжиг учир мөн эдгээр зүйлүүд

23б су Номлох.
в Хил. 12:3.
г Жером 1:12;
Алма 31:5.
25а 1 Ниф. 2:2–4.
27а су Амрах.

б су Мөнх бус, Мөнх бус байдал.
в су Мөнх бус, Мөнх бус байдал.
г Иохан 14:2–3;
Ифер 12:32–34;

С ба Г 72:4; 98:18.
[ЖЕРОМ]
1 1а 1 Ниф. 3:12; 5:14.
2а Иаков 3:14;
Омнаи 1:1.
б 1 Ниф. 6:1–6.

бидний ах дүүс “леменчүүдийн тусын тулд ‘бичигдсэн учир, иймийн тул, би багыг бичих нь зайлшгүй хэрэгтэй; гэвч би өөрийн бошиглол, бас өөрийн илчлэлтүүдийн зүйлүүдийг бичих нь үгүй. Учир нь эцэг өвгөдийнхөө бичиглэснээс илүү юуг би бичиж чадах сан билээ? Учир нь тэд авралын төлөвлөгөөг илчилсэн бус уу? Би та нарт хэлнэ, Тийм ээ; мөн энэ нь надад хангалттай.

3 Болгоогтун, тэдний зүрх сэтгэл хатуу, мөн сонор нь дүлий, мөн оюун нь харалган, мөн хүзүү нь “гөжүүд Иудейн учир, энэ хүмүүсийн дунд их зүйл хийгдэх нь зүйд нийцнэ; гэсэн хэдий ч Бурхан бол тэдэнд үлэмжийн нигүүлсэнгүй, мөн өдий болтол тэднийг энэ газрын гадаргуугаас харахан ^аарчиж зайлуулаагүй байгаа билээ.

4 Мөн олон “илчлэлт авсан нь бидний дунд олон буй, учир нь тэд бүгд гөжүүд бус. Мөн гөжүүд бус нь мөн итгэлийг агуулах тэд байж, итгэлийнх нь дагуу хүмүүний үрсэд үзүүлэх тэрхүү, Ариун Сүнстэй тэд ^бхарьцах бөлгөө.

5 Мөн эдүгээ, болгоогтун,

хоёр зуун жил улиран одов, мөн Нифайн хүмүүс уг нутагт хүчирхэг болсон бөлгөө. Тэд Мосегийн хуулийг “дагаж мөн ^бхүндэтгэлийн өдрийг Их Эзэнд ариунаар хадгалахаар хичээсэн билээ. Мөн тэд “Бурханыг хараах нь үгүй; бас тэд түүнийг ‘доромжлох нь ч үгүй. Мөн уг нутгийн хуулиуд үлэмж чанд байв.

6 Мөн тэд, мөн Леменчүүд ч түүнчлэн энэ газрын гадаргуу дээр ихэд тархсан байв. Мөн тэд нифайчуудаас тоогоор үлэмж давуу байв; мөн тэд “аллагад дурлаж мөн адгуусны цус уух бөлгөө.

7 Мөнхүү улиран тохиох дор тэд нифайчууд бидний эсрэг тулалдахаар олон удаа ирэв. Гэвч манай “хаад мөн бидний удирдагчид Их Эзэнд итгэх итгэлдээ хүчирхэг хүмүүс байв; мөн тэд Их Эзэний замуудыг хүмүүст заадаг байлаа; иймийн тул, бид леменчүүдийн эсрэг зогсож мөн тэднийг ^бнутгаасаа хөөн зайлуулж, мөн хотуудаа, эсвээс бидний өв болох аливаа газрыг бэхлэн хамгаалж эхлэв.

8 Мөн бид үлэмж өнөр өтгөн болж, мөн газрын гадаргуугаар нэг тархав, мөн алт, мөн

2в 2 Ниф. 27:6;
Морм. 5:12.
г су Судрууд—
Судруудын үнэ
цэнэ.
3а Инос 1:22–23.
б Ифер 2:8–10.
4а Алма 26:22;
Хил. 11:23;

С ба Г 107:18–19.
су Илчлэлт.
б су Ариун Сүнс.
5а 2 Ниф. 25:24;
Алма 34:13–14.
б Ег. 35:2.
су Хүндэтгэлийн
Өдөр.
в су Бүдүүлэг үг

хэллэг.
г су Доромжлох,
Доромжлол.
6а Иаков 7:24;
Инос 1:20.
7а Иаков 1:9, 11, 15.
б Морм. үгс 1:14.

мөнгө, мөн үнэт зүйлүүд, мөн сайн хийцэт модон урлал, барилгууд, бас хөдөлгүүр, мөн түүнчлэн төмөр болон ээс, мөн гууль болон ган, газар боловсруулах бүх төрлийн янз бүрийн хэрэгслүүд, мөн дайны “зэвсэг — тийм ээ, хурц үзүүрт сум, мөн чичлүүр, мөн хатгуур сум, мөн жад, бас дайны бүх бэлтгэлүүдээр үлэмж баян болсон байв.

9 Мөн тийн леменчүүдтэй тулахаар бэлтгэсэн байсан учир, тэд бидний эсрэг амжилт олсонгүй. Харин бидний эцэг өвгөдөд тэрээр ярьж, өгүүлсэн нь: Миний зарлигуудыг дагахын хэрээр та нар уг нутагт дэгжих болно хэмээсэн Их Эзэний үг нотлогдсон билээ.

10 Мөнхүү улиран тохиох дор хэрэв тэд зарлигуудыг эс дагаж, харин зөрчилд унавал, тэд энэ газрын гадаргуугаас “устгагдах ёстой гэсэн Бурханы үгийн дагуу Их Эзэний бошиглогчид Нифайн хүмүүст сануулж байсан бөлгөө.

11 Иймийн тул, бошиглогчид, мөн санваартнууд, мөн багш нар, бүх зүтгэлээрээ чармайхыг хүмүүст тэвчээртэйгээр ухуулж, шаргуу хөдөлмөрлөж байв; “Мосегийн хуулийг мөн үүний өгөгдсөн

учрыг анхааруулан сургасан ажгуу; Мессиаг ^бхарж хүлээхийг тэдэнд ятган мөн тэрээр ^ааль хэдийн байсан хэдий ч, түүнийг ирнэ гэдэгт итгэхийг ятгаж байв. Мөн ийм маягаар тэд тэдэнд зааж байлаа.

12 Мөнхүү улиран тохиох дор тэд түүнчлэн үйлдсэнээр тэднийг энэ газрын гадаргуу дээр “устгагдахаас ангижруулсан юм; учир нь тэд үгээр тэдний зүрхийг ^бзүсэж, үргэлж бусниулан наманчлалд хүргэж байв.

13 Мөнхүү улиран тохиох дор хоёр зуун гучин найман жил улиран одож — дайнууд, мөн тэмцлүүд, мөн маргаанууд цагийн ихийг эзэлсэн байв.

14 Мөн би, Жером, илүүг бичих нь үгүй, учир нь ялтсууд жижиг болой. Гэвч болгоогтун, ах дүүс минь, та нар Нифайн “бусад ялтсуудаас лавлан үзэж болно; учир нь болгоогтун, тэдгээрийн дээр хаадын бичиглэлийн дагуу, эсвээс тэдний бичүүлсэн тэдгээр дайнуудын маань тухай цэдгүүд сийлэгдсэн буй.

15 Мөн би эдгээр ялтсуудыг хүү Омнаинхаа гарт, тэдгээр нь миний өвгөдийн “зарлигуудын дагуу хадгалагдаж болохын тулд шилжүүлэх бөлгөө.

8а Мозая 10:8.
10а 1 Ниф. 12:19–20;
Омнаи 1:5.
11а Иаков 4:5;
Алма 25:15–16.

б 2 Ниф. 11:4;
Ифер 12:18–19.
в 2 Ниф. 25:24–27;
Мозая 3:13; 16:6.
12а Ифер 2:10.

б Алма 31:5.
14а 1 Ниф. 9:2–4.
15а Иаков 1:1–4.

Омнаин Ном

Омнаи, Амарон, Чемиш, Абинадом, мөн Амаликай нар ээлж дараалан цэдгүүдийг хадгалав—Зедикаягийн өдрүүдэд Иерусалимаас ирсэн, Зарахемлагийн хүмүүсийг Мозая илрүүлж мэдэв—Мозая тэдний дээр хаан суулгагдав—Мюлекийн үр удам Зарахемлад жаредчуудын сүүлч болох Кориантумрыг олж илрүүлэв—Бенжамин хаан Мозаяг залгамжлав—Христэд өгөх өргөл болгож хүмүүн өөрсдийн бодгалийг өргөл болговол зохино. Ойролцоогоор мээ 323–130 он.

БОЛГООГТУН, улиран тохиох дор би, Омнаи, өөрийн эцэг, Жеромоор, би эдгээр ялтсууд дээр удмынхаа зарим нэгэн бичгийг хадгалж үлдээхийн тулд үргэлжлүүлэн бичих ёстой хэмээн зарлигдуулсан учир—

2 Иймийн тул, миний өдрүүдэд, би өөрийн хүмүүс, нифайчуудыг өөрсдийн дайснууд леменчүүдийн гарт орохоос хамгаалахын тулд би илдээр ихэд тулалдсаныг та нар мэдээсэй хэмээнэ. Гэвч болгоогтун, би өөрөө бол хилэнцэт нэгэн, мөн би Их Эзэний зарчмууд мөн зарлигуудыг зохих ёсоор дагасан нь үгүй.

3 Мөнхүү улиран тохиох дор хоёр зуун далан зургаан жил улирч одов, мөн бид амар амгалангийн олон улирлыг

үдлээ; мөн бидэнд хүнд хэцүү дайн мөн цус урсгасан олон улирал тохиосон бөлгөө. Тийм ээ, мөн эцэст нь, хоёр зуун наян хоёр жил улирч одлоо, мөн эцэг өвгөдийнхөө “зарлигуудын дагуу эдгээр ялтсуудыг би хадгалсан билээ; мөн тэдгээрийг би хүү Амарондаа даатган шилжүүлэв. Ингээд би төгсгөө.

4 Мөн эдүгээ би, Амарон эцгийнхээ номонд өөрийн бичих цөөн зүйлийг бичье.

5 Болгоогтун, улиран тохиох дор гурван зуун хорин жил улирч, мөн нифайчуудын илүү ёс бус хэсэг нь “устгагдсан бөлгөө.

6 Учир нь Их Эзэн тэвчсэнгүй, тэрээр тэднийг Иерусалимаас удирдан гаргаад мөн тэднийг дайсныхаа гарт орохоос нь хамгаалж, хадгалсны дараа, тийм ээ, бидний эцэг өвгөдөд тэрбээр ярьсан нь: Та нар миний зарлигуудыг дагахгүй байхын хэрээр та нар уг нутагт хөгжин дэвжихгүй гэсэн тэрхүү үгс нотлогдохгүй байхыг тэрээр тэвчихгүй.

7 Иймийн тул, Их Эзэн тэдэнд агуу шийтгэлээр зочилсон ажгуу; гэсэн хэдий ч, тэрээр зөв шударгыг үйлдэгчид мөхөхгүй байхын тулд хэлтрүүлсэн, харин тэднийг дайснуудынх нь гараас чөлөөлсөн билээ.

8 Мөнхүү улиран тохиох дор

би уг ялтсуудыг дүү Чемиш-дээ дамжуулан өглөө.

9 Эдүгээ би, Чемиш, өөрийнхөө бичих цөөн зүйлийг ахынхаа бичсэнтэй адилаар уг номонд бичиглэв; учир нь болгоогтун, би түүний бичсэний сүүлчийг, тэрээр үүнийг өөрийн гараар бичсэнийг харсан билээ; мөн тэр тэдгээрийг надад дамжуулсан тэр өдөр үүнийг бичсэн бөлгөө. Мөн ийм маягаар бид цэдгүүдийг хадгалдаг, учир нь бидний эцэг өвгөдийн зарлигуудын дагуу буюу. Мөн би төгсгөлийг үйлдье.

10 Болгоогтун, би, Абинадом, Чемишийн хүү билээ. Болгоогтун, улиран тохиох дор миний хүмүүс болох нифайчууд, мөн леменчүүдийн хооронд болсон их дайн хийгээд тэмцлүүдийг би үзэв; мөн би, илдээрээ, ах дүүсээ өмгөөлөн олон леменчүүдийн амийг авсан билээ.

11 Мөн болгоогтун, энэ хүмүүсийн цэдэг үеэс үед дамжин, хаадад байх ялтсууд дээр сийлэгдсэн бөлгөө; мөн би бичиглэгдсэнээс гадуур ямар ч илчлэлт бас бошиглолыг эс мэднэ; иймийн тул, хангалттай нь бичигдсэн болой. Мөн би төгсгөлийг үйлдье.

12 Болгоогтун, би Амаликай, Абинадомын хүү болой. Болгоогтун, Зарахемлагийн нутагт хаан суулгагдсан Мозаягийн талаар зарим зүйлийг би та нарт ярих болно; учир

нь болгоогтун, түүнийг “Нифайн нутгаас зугтан гарвал зохино гэж мөн Их Эзэний дуу хоолойг сонсох тэр бүгд түүнчлэн түүнтэй хамт аглаг буйдад ⁶одвол зохино хэмээн тэрээр Их Эзэнээр сэрэмжлүүлэгдсэн учир —

13 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Их Эзэн түүнд зарлигласны дагуу үйлдсэн болой. Мөн Их Эзэний дуу хоолойг сонссон болгон, тэд уг нутгаас аглаг буйдад зайлан одов; мөн тэд олон сургаал мөн бошиглолудаар удирдагддаг байсан бөлгөө. Мөн тэд үргэлж Бурханы үгээр сургагдсан байв; мөн тэд аглаг буйдын дундуур Зарахемлагийн нутаг гэж нэрлэгдсэн тэр нутагт тэд уруудан иртлээ түүний мутрын хүчээр удирдагдсан ажээ.

14 Мөн тэд “Зарахемлагийн хүмүүс гэж нэрлэгдсэн, тэрхүү хүмүүсийг олж мэдэв. Эдүгээ, Зарахемлагийн хүмүүсийн дунд агуу их баяр хөөр байв; мөн Их Эзэн Мозаягийн хүмүүсийг иудейчүүдийн цэдгийг агуулсан ⁶гуулин ялтсуудын хамт илгээсний учир, Зарахемла түүнчлэн үлэмж баяртай байв.

15 Болгоогтун, улиран тохиох дор Иудейн хаан, “Зедикая Вавилонд боолчлолд аваачигдсан тэр үед Зарахемлагийн ⁶хүмүүс Иерусалимаас гарч ирснийг Мозая олж мэдэв.

12а 2 Ниф. 5:6–9.

б Иаков 3:4.

14а су Зарахемла.

б 1 Ниф. 3:3, 19–20;

5:10–22.

15а Иер. 39:1–10;

Хил. 8:21.

б Мозая 25:2.

16 Мөн тэд аглаг буйдад аялж, мөн Их Эзэний мутраар их усыг туулан Мозая тэднийг олсон тэр нутагт авчрагдсан байлаа; мөн тэд тэр цагаас хойш тэнд оршин суусан бөлгөө.

17 Мөн Мозая тэднийг олсон тэр цагт, тэд тоолшгүй олон болсон байв. Гэсэн хэдий ч, тэдэнд олон дайн мөн ширүүн тэмцлүүд байв, мөн цагаас цагт илдэнд эрсдэж унасаар байжээ; мөн тэдний хэл гуйвуулагджээ; мөн тэд өөрсөдтэйгөө “цэдгүүдийг авчирсан нь үгүй; мөн тэд өөрсдийг нь Бүтээгч байдгийг үгүйсгэсэн бөлгөө; мөн тэднийг Мозая ч, бас Мозаягийн хүмүүс ч ойлгож эс чадсан буюу.

18 Гэвч улиран тохиох дор Мозая, тэд түүний хэлийг заалгавал зохино хэмээв. Мөнхүү улиран тохиох дор тэд Мозаягийн хэлийг заалгасны дараа, Зарахемла эцэг өвгөдийнхөө уг удмыг дурсамжийнхаа дагуу өгөв; мөн тэдгээр нь бичигдсэн, харин эдгээр ялтсуудад бус болой.

19 Мөнхүү улиран тохиох дор Зарахемлагийн мөн Мозаягийн хүмүүс “хамтран нэгдэв; мөн ^бМозая тэдний хаан байхаар тохоогдов.

20 Мөнхүү улиран тохиох дор Мозаягийн өдрүүдэд, дээр нь сийлбэр бүхий том

чулуу байсан нь түүнд авчрагдсан байв; мөн тэрээр уг сийлбэрийг Бурханы бэлэг болон хүчээр “хөрвүүлсэн бөлгөө.

21 Мөн тэдгээр нь “Кориантумр гэгч нэгний мөн түүний хүмүүсийн алагдагсдын шастырыг өгүүлэв. Мөн Кориантумр нь Зарахемлагийн хүмүүсээр олж мэдэгдсэн байв; мөн тэрээр тэдэнтэй есөн сарын турш оршсон буюу.

22 Энэ нь түүнчлэн түүний эцэг өвгөдийн талаар цөөн үгсийг өгүүлсэн бөлгөө. Мөн түүний анхны эцэг эх нь Их Эзэн хүмүүсийн хэлийг “будлиулсан тэр цагт, уг ^бцамхгаас ирсэн буюу; мөн Их Эзэний ял түүний шударга шүүлтийн дагуу тэдэн дээр оногдсон ажгуу; мөн тэдний “яснууд нутгийн умардад таран хэвтэх аж.

23 Болгоогтун, би, Амаликай, Мозаягийн өдрүүдэд төрсөн билээ; мөн би түүний үхлийг үзтэлээ амьдарч байв; мөн түүний хүү, “Бенжамин, түүний оронд засаглан суух бөлгөө.

24 Мөн болгоогтун, хаан Бенжаминны өдрүүдэд, нифайчууд мөн леменчүүдийн дунд ширүүн дайн мөн их цус урсахыг би үзэв. Гэвч болгоогтун, Нифайчууд тэднийг ихэд давамгайлах байдалд хүрэв; тийм ээ, үүний хэрээр

17a Мозая 1:2–6.

19a Мозая 25:13.

б Омнаи 1:12.

20a Мозая 8:13–19.

су Үзмэрч.

21a Ифер 12:1.

су Кориантумр.

22a Эхл. 11:6–9;

Мозая 28:17;

Ифер 1:33.

б Ифер 1:1–5.

в Мозая 8:8.

23a Мор. үгс 1:3.

хаан Бенжамин тэднийг За-
рахемлагийн нутгаас зайлуу-
лан гаргасан бөлгөө.

25 Мөнхүү улиран тохиох
дор би өтөлж эхлэв; мөн үр
удам үгүй байв, мөн хаан
“Бенжамин Их Эзэний өмнө
шударга хүн болохыг мэдэ-
хийн учир, иймийн тул, би
эдгээр ялтсуудыг түүнд
^бдамжуулан, бүх хүмүүнийг
Израилын Ариун Нэгэн,
Бурханд ирж, мөн бошигло-
луудад мөн илчлэлтүүдэд,
мөн тэнгэр элчүүдийн тохи-
нуулалд, мөн хэлээр ярихын
бэлэгт, мөн хэлийг хөрвүүлэ-
хийн бэлэгт мөн “сайн болох
тэр бүх зүйлүүдэд итгэхийг
ятгах болно; учир нь Их
Эзэнээс ирээгүй л бол ямар
ч сайн нь үгүй: мөн хилэнцэт
тэр нь чөтгөрөөс ирдэг
бөлгөө.

26 Мөн эдүгээ, хайрт ах дүүс
минь, та нарыг Израилын
Ариун Нэгэн болох Христэд
“ирж, мөн түүний авралаас
мөн түүний гэтэлгэлийн хүч-
нээс хүртээсэй хэмээнэ би.
Тийм ээ, түүнд ирэгтүн, мөн
өөрийн бүхэл бодгалийг
түүнд ^бөргөл болгон ^бөгөгтүн,
мөн ^вмацаг барьж бас зал-
бирахаа үргэлжлүүл, мөн

эцсийг хүртэл тэвчигтүн; мөн
Их Эзэн амьдардгийн адил
та нар аврагдах болно.

27 Мөн эдүгээ би Нифайн
нутагт буцахаар аглаг буй-
дад одсон хэдэн тооны хү-
мүүсийн талаар заримыг
ярья; учир нь өвлөсөн нутгаа
эзэмших хүсэлтэй нь олон
байв.

28 Иймийн тул, тэд аглаг
буйдад одсон юм. Мөн тэд-
ний удирдагч хүчтэй бас
чадалтай хүн, мөн зөрүүд
нэгэн байлаа, иймийн тул
тэрээр тэдний дунд маргаан
үүсгэсэн ажгуу; мөн тэд аглаг
буйдад тавиас бусад нь бүгд
“алагдаж, мөн тэд Зарахем-
лагийн нутагт, эргэж ирсэн
бөлгөө.

29 Мөнхүү улиран тохиох дор
тэд түүнчлэн нилээд олон
тооны хүмүүнийг аваад, мөн
дахин аглаг буйдад аянаа
хөөв.

30 Мөн Амаликай, би дүүтэй
байлаа, түүнчлэн тэдэнтэй
хамт явав; мөн түүнээс хойш
тэдний талаар мэдсэнгүй
билээ. Мөн би бараг доош
булшиндаа хэвтэх минь дө-
хөж; мөн “эдгээр ялтсууд
дүүрчээ. Мөн би яриагаа
төгсгөл болгоё.

25a Мор. үгс 1:17–18;
Мозая 29:13.
б Мор. үгс 1:10.
в Алма 5:40;
Ифер 4:12;

Моро. 7:15–17.
26a Иаков 1:7;
Алма 29:2;
Моро. 10:32.
б 3 Ниф. 9:20.

в су Золиослол.
г су Мацаг барих,
Мацаг барилт.
28a Мозая 9:1–4.
30a 1 Ниф. 6:1–6.

МОРМОНЫ ҮГС

Мормон Нифайн том ялтсуудыг хураангуйлав—Тэрээр бага ялтсуудыг бусад ялтсуудтай хамт тавив—Хаан Бенжамин уг нутагт энх амгаланг тогтоов. Ойролцоогоор мэ 385 он.

МӨН эдүгээ би, “Мормон, хийсэн цэдгээ Моронай хүүгийнхээ гарт дамжуулан өгөх гэж байна, болгоогтун би өөрийн хүмүүс, нифайчуудын бараг л бүх устгалыг гэрчилсэн бөлгөө.

2 Мөн энэ нь Христийн ирэлтээс “олон зуун жилийн дараа би эдгээр цэдгүүдийг хүүгийнхээ гарт дамжуулна; мөн тэрээр миний хүмүүсийн бүх устгалыг үзэх болно хэмээн надад санагдана. Гэвч тэрээр тэдгээрийн талаар зарим зүйлийг, мөн Христийн талаар зарим зүйлийг бичиж болно, хэзээ нэгэн өдөр энэ нь тэдний ⁶тусын төлөө байж болохын тулд Бурхан тэднийг гэтэлгэн амьд үлдэхийг зөвшөөрдөг ч болоосой.

3 Мөн эдүгээ, би бичиглэснийхээ талаар зарим зүйлийг ярья; учир нь би Нифайн “ялтсуудаас Амаликайн ярьсан хаан Бенжаминь хаанчлалыг хүртэлх ⁶хураангуйллыг хийснийхээ дараа, гарт минь

дамжуулагдсан уг ⁶цэдгүүдийн дунд би хайж, мөн Иаков энэхүү хаан ‘Бенжаминь хаанчлалыг хүртэлх бошиглогчдын бага цэдгийг мөн түүнчлэн Нифайн олон үгсийг агуулсан эдгээр ялтсуудыг олсон бөлгөө.

4 Мөн эдгээр ялтсууд дээрх зүйлүүд нь Христийн ирэлтийн тухай бошиглолууд учир намайг “баясгана; мөн миний эцэг өвгөд тэр болгон нь биелэгдсэнийг мэддэг бөлгөө; тийм ээ, энэ өдрийг хүртэлхийг тухайлан бидний талаар бошиглогдсон зүйлүүд болгон нь биелэгдсэнийг би түүнчлэн мэднэ, мөн энэ өдрөөс цааших нь гарцаагүй улиран тохиох ёстой—

5 Иймийн тул, би дээр нь өөрийн цэдгийг дуусгахаар “эдгээр зүйлийг, Нифайн ⁶ялтсуудаас авах тэр үлдсэн хэсгийг сонгосон бөлгөө; мөн би өөрийн хүмүүсийн тухай зүйлүүдээс ⁶зууны нэг хэсгийг нь ч бичиж чадахгүй болой.

6 Гэвч болгоогтун, би эдгээр бошиглолууд мөн илчлэлтүүдийг агуулсан, эдгээр ялтсуудыг авах болно, мөн өөрийн цэдгийн үлдэгдэлтэй хамт тэдгээрийг хийнэ, учир

[мормоны үг]

1 1а 3 Ниф. 5:9–12;
Морм. 1:1–4; 8:1, 4–5.
су Мормон,
нифайчуудын
бошиглогч.
2а Морм. 6:5–6.
б С ба Г 3:16–20.

3а С ба Г 10:38–40.
б С ба Г 10:44.
в Мозая 1:6;
Хил. 3:13–15;
Морм. 4:23.
г Омнай 1:23.
4а 1 Ниф. 6:5.
5а ө.х. (Шүлэг 4-т

дурдагдсан)
түүний таалалд
нийцэх зүйлс.
б 1 Ниф. 9:2.
в 3 Ниф. 5:8–11;
26:6–12.

нь тэдгээр нь надад сонгомол болой; мөн тэдгээр нь ах дүүсийн минь хувьд ч сонгомол байх болно гэдгийг би мэднэ.

7 Мөн би үүнийг “мэргэн зорилгын учир хийх бөлгөө; өөрөөр хэлбэл энэ нь, надад байх Их Эзэний Сүнсний нөлөөний дагуу надад ийн шивнэнэ. Мөн эдүгээ, би бүх зүйлийг мэдэхгүй; гэвч Их Эзэн ирэх бүх зүйлийг ^бмэднэ; иймийн тул, тэрээр тааллынхаа дагуу надад оршин ажиллах буюу.

8 Мөн Бурханд хандсан “залбирал минь миний ах дүүсийн талаар, тэд дахин нэгэнтээ Бурханы, тийм ээ, Христийн гэтэлгэлийн мэдлэгт орж болохын тулд буюу; тэд дахин нэгэнтээ ^ббахдам сайхан хүмүүс байж болохын тулд буюу.

9 Мөн эдүгээ би, Мормон, Нифайн ялтсуудаас өөрийн авах тэрхүү цэдгийг дуусгахаар зорьё; мөн би үүнийг Бурхан надад өгсөн тэр мэдлэг хийгээд ойлголтын дагуу хийх болно.

10 Иймийн тул, улиран тохиох дор Амаликай эдгээр ялтсуудыг хаан Бенжамины гарт “дамжуулан өгсний дараа, тэрээр тэдгээрийг авч мөн үеэс үед хаан Бенжамины өдрүүдийг хүртэл ^бхаадаар дамжуулагдан ирсэн ^бтэрхүү

цэдгүүдийг агуулсан бусад ялтсуудтай хамт тавилаа.

11 Мөн хаан Бенжаминаас доош үеэс үед тэдгээр нь “миний гарт ортлоо гардуулагдсан бөлгөө. Мөн би, Мормон, тэдгээр нь энэ цагаас хойшид ч хадгалагдан үлдэж болохын төлөө Бурханд залбирдаг. Мөн тэдгээр нь хамгаалагдах болно гэдгийг би мэднэ; учир нь тэдгээрийн дээр чухам түүнээс миний хүмүүс мөн тэдний ах дүүс агуу хийгээд эцсийн өдөр, бичигдсэн буй Бурханы үгийн дагуу ^бшүүгдэх агуу зүйлүүд бичиглэгдсэн буй.

12 Мөн эдүгээ, энэ хаан Бенжамины талаар—түүний хүмүүсийн дунд зарим зөрчлүүд байв.

13 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн их цэрэг түүнчлэн түүний хүмүүсийн эсрэг байлдахаар Нифайн “нутгаас уруудан ирэв. Гэвч болгоогтун, хаан Бенжамин их цэргээ нэгтгэн цуглуулж, мөн тэрээр тэдний эсрэг зогсов; бас тэрээр гарынхаа хүчээр, Лебений ^билдээр тулалдсан бөлгөө.

14 Мөн Их Эзэний хүчээр тэд дайснуудынхаа эсрэг, леменчүүдээс олон мянгыг устгах хүртэл тэмцэлдсэн билээ. Мөнхүү улиран тохиох дор тэд леменчүүдийн эсрэг тэднийг

7а 1 Ниф. 9:5; 19:3;
С ба Г 3:12–20;
10:1–19, 30–47.
б су Бүхнийг Мэдэгч.
8а 2 Ниф. 33:3–4;
Инос 1:11–12.
б 2 Ниф. 30:6.

10а Омнай 1:25, 30.
б Жером 1:14.
в 1 Ниф. 9:4.
11а 3 Ниф. 5:8–12;
Морм. 1:1–5.
б 2 Ниф. 25:18; 29:11;
33:11–15;

3 Ниф. 27:23–27.
13а Омнай 1:12.
б 1 Ниф. 4:9;
2 Ниф. 5:14;
Иаков 1:10;
Мозая 1:16;
С ба Г 17:1.

өвлөсөн бүх нутгаасаа хөөн гаргатлаа тэмцэлдсэн болой.

15 Мөнхүү улиран тохиох дор хуурамч “Христүүд байв, мөн тэдний ам хамхигдаж, мөн тэд гэмт хэргүүдийнхээ дагуу шийтгэгдсэний дараа;

16 Мөн хуурамч бошиглогчид, мөн хуурамч номлогчид, бас багш нар хүмүүсийн дунд байв, мөн тэд бүгд гэмт хэргүүдийнхээ дагуу шийтгэгдсэний дараа; мөн олон маргаан болж мөн олон нь леменчүүдэд урваж одсоны дараа, болгоогтун, улиран тохиох дор хаан Бенжамин, түүний хүмүүсийн дунд байсан ариун “бошиглогчдын тусламжтайгаар—

17 Учир нь болгоогтун, хаан Бенжамин “ариун хүн байв, мөн тэрээр өөрийн хүмүүсийн дээр зөв шударгаар засаглаж байв; мөн уг нутагт ариун хүмүүс олон байлаа, мөн тэд Бурханы үгийг “хүчтэйгээр мөн эрх мэдэлтэйгээр ярьдаг байв; мөн хүмүүсийн зөрүүдийн учир тэд ихэд “хурцыг хэрэглэж байв—

18 Иймийн тул, тэдний тусламжтайгаар, хаан Бенжамин мөн түүнчлэн бошиглогчид маханбодийнхоо бүх хүч чадлаар мөн оюуныхаа бүх чадвараар хөдөлмөрлөснөөр, уг нутагт энх амгаланг дахин нэгэнтээ тогтоожээ.

Мозаягийн Ном

БҮЛЭГ 1

Хаан Бенжамин өөрийн хөвгүүдэд эцэг өвгөдийнх нь хэлийг мөн бошиглолыг сургаж—Тэдний шашин мөн соёл иргэншил нь өөр өөр ялтсууд дээрх цэдгүүдийн учир хадгалагдсан байдаг—Мозая хаанаар сонгогдэв мөн цэдгүүд болон бусад зүйлүүд хамгаалан хадгалагдахаар өгөгдөв. Ойролцоогоор мэв 130–124 он.

МӨН эдүгээ Зарахемлагийн бүх “нутагт, хаан Бенжаминд харъяалагдах бүх

хүмүүсийн дунд дахин зөрчилдөөн огт байсангүй, иймээс хаан Бенжамин өөрийн үлдсэн бүх өдрийг үргэлжийн амгаланд өнгөрөөв.

2 Мөнхүү улиран тохиох дор түүнд гурван хүү байв; мөн тэрээр тэднийг Мозая, мөн Хилорум, Хиламан хэмээн нэрлэв. Мөн тэрээр тэд ойлголтыг агуулсан хүмүүс болж болохын тулд тэд эцэг өвгөдийнхөө бүх “хэлэнд “сургагдахаар болгов; мөн тэдний эцэг өвгөдийн амаар яригдсан, тэдэнд Их Эзэний мутраар

15а су Христийн эсрэг.

16а Инос 1:22.

17а Алма 13:26.

б Алма 17:2–3.

в Моро. 9:4;

С ба Г 121:41–43.

[МОЗАЯ]

1 1а Омнаи 1:13.

2а Мозая 4:14–15;

С ба Г 68:25, 28.

б Морм. 9:32.

өгөгдсөн бошиглолуудын талаар тэд мэдэж болно хэмээсний тул болой.

3 Мөн түүнчлэн тэрээр гуулин ялтсууд дээр сийлэгдсэн цэдгүүдийн талаар тэдэнд зааж, хэлсэн нь: Хөвгүүд минь, та нар эдгээр цэдгүүд мөн эдгээр зарлигуудыг тээсэн эдгээр “ялтсууд байгаагүй аваас бид ⁶мэдэхгүйдээ зовох ёстой сон, бүр одоо цагт ч гэсэн, Бурханы нууцуудыг мэдэхгүй байсных гэдгийг та нарыг санаасай хэмээнэ би.

4 Учир нь эдгээр ялтсуудын тусламжгүй аваас бидний эцэг Лихай хүүхдүүддээ сургахын тулд эдгээр бүх зүйлийг цээжилж чадах нь боломжгүй байсан юм; учир нь тэрээр Египетийн “хэлийг заалгасан байсан аж тиймийн тул тэрээр эдгээр сийлбэрүүдийг уншиж чадаад мөн тэдгээрийг хүүхдүүддээ заажээ, тэгээд тэд түүгээр нь хүүхдүүддээ зааж чадсан аж, мөн ингэснээр Бурханы зарлигуудыг, бүр одоо цагийг хүртэл биелүүсээр иржээ.

5 Би та нарт хэлнэ, хөвгүүд минь, бид түүний “нууцуудыг ⁶уншиж мөн ойлгож болохын тулд, мөн түүний зарлигууд үргэлж бидний нүдний өмнө байж болохын тулд Бурханы мутраар хамгаалагдаж бас ⁶хадгалагдсан, эдгээр зүйлүүд

байгаагүй аваас бүр бидний эцэг өвгөд итгэлгүйдээ доройтох бөлгөө, мөн бид эдгээр зүйлүүдийн талаар юу ч мэдэхгүй, эсвээс бүр эдгээрт үл итгэх тэр нь заагдсан байсан ч эцэг өвгөдийнхөө зөв бус ‘уламжлалын учир өөрсдийн ах дүүс болох леменчүүдийн адил байх байсан биз ээ.

6 Ай хөвгүүд минь, эдгээр хэллэгүүд үнэн, мөн түүнчлэн эдгээр цэдгүүд “үнэн гэдгийг та нар санаасай хэмээнэ би. Мөн болгоогтун, түүнчлэн тэд Иерусалимыг орхисон тэр цагаас одоог хүртэл бидний эцэг өвгөдийн цэдгүүд мөн хэллэгүүдийг тээсэн, Нифайн ялтсууд, тэдгээр нь үнэн; мөн бид тэдгээрийн гарцаагүйг мэдэж чадахын учир нь тэдгээр нь бидний нүдний өмнө байна.

7 Мөн эдүгээ, хөвгүүд минь, та нар тэдгээрийг ашиглаж болохын тулд та нар тэдгээрийг хичээнгүйлэн “судлахыг санаасай хэмээнэ би; мөн бидний эцэг өвгөдөд өгсөн Их Эзэний ⁶амлалтуудын дагуу та нар энэ нутагт ⁶дэгжихийн тулд, та нар Бурханы ‘зарлигуудыг дагаасай хэмээнэ би.

8 Мөн хаан Бенжамин энэ номонд бичигдээгүй өөр олон зүйлийг хөвгүүддээ заасан ажээ.

9 Мөнхүү улиран тохиох

3а су Ялтсууд.
б Алма 37:8–9.

4а ИС—Т 1:64.

5а су Судрууд—
Хадгалагдсан
судрууд.

б Дэд хууль 6:6–8.

в су Бурханы
нууцууд.

г Мозая 10:11–17.

6а 1 Ниф. 1:3;
2 Ниф. 33:10–11;
Моро. 10:27.

7а су Судрууд.

б Мозая 2:22;
Алма 50:20–22.

в Дуул. 122:6;
1 Ниф. 2:20.

г Алма 9:12–14.

дор хаан Бенжамин хөвгүүд дээ сургахаа төгсгөл болгосны дараа, тэр өтлөв, мөн тэрээр тун удахгүй бүх хорвоогийн жамаар одох ёстойгоо мэдсэн аж; тиймийн тул, тэр хаант улсыг хөвгүүдийнхээ нэгний нь мэдэлд шилжүүлэх нь зохистой хэмээн боджээ.

10 Тиймийн тул, тэрээр Мозаяг өөрийн өмнө авчруулав; мөн эдгээр нь түүнд хэлсэн түүний үгс бөлгөө, хэлрүүн: Хүү минь, та нар энэ бүх нутаг даяар бүх хүмүүсийн, өөрөөр хэлбэл уг нутагт орших Зарахемлагийн бүх “хүмүүсийн, мөн Мозаягийн тэд цугларсан байж болохын тулд хүмүүсийн дунд зар бичиг тараагаасай хэмээнэ би; учир нь маргааш би өөрийн энэ хүмүүст өөрийн амаар чамайг Их Эзэн Бурханы минь бидэнд өгсөн хүмүүсийн удирдагч мөн ^бхаан гэдгийг тунхаглах болно.

11 Мөн үүнээс гадна, тэд Их Эзэн Бурхан Иерусалим нутгаас гарган авчирсан бүх хүмүүсийн дээгүүр онцлогдож болохын тулд би энэ хүмүүст “нэр өгөх болно; мөн тэд Их Эзэний зарлигуудыг дагахдаа хичээнгүй байсаар буй хүмүүс учир би үүнийг хийнэ.

12 Мөн “зөрчилд байхаас бусдаар хэзээ ч арилгагдахгүй нэрийг би тэдэнд өгнө.

13 Тийм ээ, мөн үүнээс гадна би чамд хэлнэ, хэрэв Их Эзэн

ихээр таалсан энэ хүмүүс “зөрчилд унах аваас, мөн ёс бус болон садар самуун хүмүүс болбоос, Их Эзэн тэднийг бусдын гарт оруулна, тэгснээр тэд өөрсдийн ах дүүс шиг ^бсул дорой болох болно; мөн тэрээр тэднийг дахин өөрийн зүйрлэшгүй мөн гайхамшигт хүчээрээ бидний эцэг өвгөдийг одоо болтол “хамгаалсан шигээ хамгаалах нь үгүй.

14 Учир нь би та нарт хэлнэ, хэрэв тэрээр мутраа бидний эцэг өвгөдийн өмгөөллийн төлөө сунгаагүй бол тэд леменчүүдийн гарт орж, мөн тэдний өс хонзонгийн золиос болох байсан нь гарцаагүй буйза.

15 Мөнхүү улиран тохиох дор хаан Бенжамин хүүдээ хандсан эдгээр үгсээ төгсгөл болгосны дараа, хаант улсын бүх хэргийн талаарх хариуцлагыг тэрээр түүнд өгөв.

16 Мөн үүнээс гадна, тэрээр түүнчлэн “гуулин ялтсууд дээр сийлэгдсэн цэдгүүдийн талаарх хариуцлагыг; мөн түүнчлэн Нифайн ялтсуудыг; мөн түүнчлэн, Лебений ^билдийг, мөн бидний эцэг өвгөдийг аглаг буйд дундуур удирдсан, түүгээр тэд хүн бүр түүнд хандуулсан анхаарал мөн хичээнгүйллийн дагуу удирдаж болохын тулд Их Эзэний мутраар бэлтгэгдсэн, тэрхүү ^ббөмбөрцөг, өөрөөр

10a Омнаи 1:14.

б Мозая 2:30.

11a Мозая 5:8–12.

12a су Нүгэл.

13a Евр. 6:4–6.

б Хил. 4:24–26.

в С ба Г 103:8–10.

16a Мозая 1:3.

б 1 Ниф. 4:8–19;

Мор. үгс 1:13;

С ба Г 17:1.

в 1 Ниф. 16:10.

хэлбэл тэр зүг чиг заагчийг түүнд өгөв.

17 Тиймийн тул, тэд итгэлгүйнхээ хэрээр дэгжиж бас аян замдаа урагшлах нь үгүй, харин “буцаж туугдсан билээ, мөн Бурханы дургүйцлийг өөрсдийнхөө дээр авчирсан юм; мөн тиймийн тул тэд өлсгөлөн мөн зовлон зүдрэлүүдэд цохигдож, өөрсдийнх нь үүрэг сануулагдахын тулд тараагдсан бөлгөө.

18 Мөн эдүгээ, улиран тохиох дор Мозая явж мөн эцгийнхээ өөрт нь зарлигласныг хийж, мөн тэд эцгийнхээ өөрсдөд нь ярих үгсийг сонсохын тулд ариун сүм өөд явахаар нэгдэн цугларч болохын тулд Зарахемла нутагт байсан бүх хүмүүст тунхаглав.

БҮЛЭГ 2

Хаан Бенжамин өөрийн хүмүүст хандан айлтгав—Тэрээр өөрийн хаанчлалын тэгш эрх, үнэн ариун байдал хийгээд сүнслэг чанарыг тоочив—Тэнгэрлэг Хаандаа үйлчлэхийг тэрээр тэдэнд зөвлөв—Бурханы эсрэг тэмцэх тэд унтаршгүй гал мэт тарчлал эдлэх болно. Ойролцоогоор мөө 124 он.

Мөнхүү улиран тохиох дор Мозая эцгийнхээ өөрт нь зарлиг болгосныг хийж, мөн бүх нутаг даяар зар бичгийг

түгээсний дараа хаан Бенжамин тэдэнд ярих үгсийг сонсохоор тэд ариун сүм өөд очиж болохын тулд бүх нутаг даяар хүмүүс цугларав.

2 Мөн агуу олон тоотой, бүр тэд тэднийг тоолшгүй тийм олон байв; учир нь тэд үлэмж өнөржиж мөн уг нутаг агуу болсон бөлгөө.

3 Мөн тэд түүнчлэн “сүргийнхээ ууган төлийг тэд ⁶Мосегийн хуулийн дагуу ⁶тахил өргөж, мөн ⁶өргөл хайлж болох хэмээн авчээ;

4 Мөн түүнчлэн тэд Иерусалим нутгаас тэднийг авчирсан, мөн тэднийг дайснуудынх нь гараас чөлөөлж, мөн Зарахемла “нутагт амгаланг тогтоосон, мөн тэд баясаж мөн Бурханд болон бүх хүмүүст хандсан ⁶хайраар дүүргэгдэж болохын тулд Бурханы “зарлигуудыг дагахыг тэдэнд сургасан шударга хүмүүнийг тэдний ⁶багш нар байхаар, мөн түүнчлэн шударга хүнийг тэдний хаан байхаар ⁶томилсон, өөрсдийн Бурхан, Их Эзэнд талархлаа илэрхийлж болохын тулд буюу.

5 Мөнхүү улиран тохиох дор тэд ариун сүм өөд ирээд, тэд майхнуудаа эргэн тойронд босгож, хүн бүр эхнэр, мөн хөвгүүдээ, мөн охидоо, мөн тэдний хөвгүүд, мөн тэдний охидоос бүрдсэн ахмадаас нь бага хүртэл, “гэр бүлээрээ,

17a 1 Ниф. 18:12–13.

2 3a Эхл. 4:4.

б 2 Ниф. 25:24;

Алма 30:3; 34:13–14.

в су Золиослол.

г 1 Ниф. 5:9.

4a Омнаи 1:12–15.

б су Хайр.

в Иохан 15:10.

г Мозая 18:18–22.

су Заах, Багш.

д су Дуудах,

Бурханаас

дуудагдах,

Дуудлага.

5a су Гэр бүл.

гэр бүл болгон нэг нь нөгөөгөөсөө тусдаа байрлав.

6 Мөн тэд майхнуудаа ариун сүмийн эргэн тойронд босгож, хүн болгон “майхныхаа амыг ариун сүмийг чиглүүлэв, тэгснээр тэд майхнууддаа үлдэн мөн хаан Бенжамин тэдэнд ярих үгсийг сонсож байв.

7 Учир нь олон түмэн маш их байсны учир хаан Бенжамин тэд бүгдэд ариун сүмийн ханан дотор багтаан зааж чадсангүй, тиймийн тул хүмүүс түүний тэдэнд ярих тэр үгсийг сонсож болохын тулд тэрээр цамхаг босгуулав.

8 Мөнхүү улиран тохиох дор тэрээр өөрийн хүмүүст цамхагас ярьж эхлэв; мөн тэд бүгд түүний үгсийг сонсож чадсангүйн учир нь хүний олноос бөлгөө; тиймийн тул тэрээр өөрийн ярьсан үгсийг бичүүлж мөн түүний дуу хүрэхгүй газар байгаа тэд түүнчлэн үгсийг нь хүлээн авч болохын тулд тэдний дунд илгээлгэв.

9 Мөн эдгээр нь түүний “ярьсан мөн бичүүлсэн үгс буюу, хэлсэн нь: Ах дүүс минь, энэ өдөр та нарт миний ярих үгсийг сонсож болохын тулд, та бүгд өөрсдөө чуулжээ; өөрөөр хэлбэл та нарыг нааш ирж миний ярих үгсийг ^бтохуурхахыг би зарлиг болгоогүй, харин та нар намайг анхааран ^всонсогтун, мөн та нар сонсож болохын тулд сонороо дэлгэг-

түн, мөн ойлгож болохын тул ^ззүрх сэтгэлээ нээгтүн, мөн та нарын ^дтөсөөлөлд Бурханы “нууцууд дэлгэгдэж болохын тулд оюунаа нээгтүн.

10 Би та нарыг надаас “айх ёстой хэмээн, эсвээс та нар намайг зуурдын хүнээс илүү гэж бодох ёстой учир нааш ирэхийг зарлиг болгосонгүй.

11 Харин би та нарын адил, биед мөн оюунд байх янз бүрийн мөн сул дорой байдлын харьяат болой; гэвч би энэ хүмүүсээр сонгогдож, мөн эцгээрээ адислагдан томилогдсон билээ, мөн энэ хүмүүсийн дээр хаан хийгээд захирагч байхын тулд Их Эзэний мутраар зөвшөөрөгдсөн буюу; мөн Их Эзэн надад хайрласан бүхий л хүч, оюун мөн чадлаараа та бүхэнд үйлчлэхээр түүний зүйрлэшгүй хүчээр хадгалагдаж мөн хамгаалагдсаар буй.

12 Би та нарт хэлье, өөрийн өдрүүдэд та нарт үйлчлэхээр зөвшөөрөгдөн, бүр энэ цагийг хүртэл, мөн та нараас “алт бас мөнгө ч, мөн ямар ч баялгуудыг эрэлхийлээгүй болой;

13 Мөн та нар гянданд хоригдохыг, мөн та нар нэг нэгнээ боол болгохыг, мөн та нар аллага, эсвээс дээрэм буюу хулгай хийхийг, эсвээс садар самууныг үйлдэхийг би зөвшөөрөөгүй; бүр та нарыг ямар нэгэн байдлаар ёс бусыг үйлдэхийг би зөвшөөрөөгүй,

6а Ег. 33:8–10.

9а Мозая 8:3.

б С ба Г 6:12.

в су Сонсох.

з Мозая 12:27;

д Ниф. 19:33.

д су Оюун.

е су Бурханы

нууцууд.

10а су Айдас.

12а Үйлс 20:33–34.

мөн та нарт түүний зарлиг болсон бүх зүйлд Их Эзэний зарлигуудыг та нар дагах ёстой хэмээн та нарт заасан бөлгөө—

14 Мөн би бүр, өөрөө, та нарт би үйлчилж болохын тулд, мөн та нар татваруудад дарагдахгүй байхын тулд, мөн үүрэхэд хүнд юухан ч та нарын дээр үгүй байхын тулд өөрийн гараар “хөдөлмөрлөсөн—мөн миний ярьсан эдгээр бүх зүйлийн гэрчлэгч нь та нар өөрсдөө шүү дээ.

15 Гэвч, ах дүүс минь, би эдгээр зүйлийг бардамнан сайрхаж болохын тулд хийсэн бус, бас би эдгээр зүйлийг түүгээр би та нарыг зэмлэхийн тулд хэлж буй бус; харин энэ өдөр Бурханы өмнө би цэвэр “ухамсартайгаар хариулж чадахыг минь та нар мэдэж болохын тулд би эдгээр зүйлийг та нарт хэллээ.

16 Болгоогтун, би та нарт хэлнэ, би та нарт өөрийн өдрүүдийг та нарт үйлчлэхэд зориулсан гэж би хэлсний учир, би бардамнан сайрханыг хүсэх минь үгүй, учир нь би зөвхөн Бурханд үйлчилж байсан бөлгөө.

17 Мөн болгоогтун, би та нарт эдгээр зүйлийг та нар “мэргэн ухааныг сурч болохын тулд хэллээ; та нар ^ббусдадаа “үйлчилж байгаа нь та

нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу.

18 Болгоогтун, та нар намайг хаанаа болгосон; мөн хэрэв би та нарын хаан болгосон тэрбээр, та нарт “үйлчлэхээр хөдөлмөрлөх аваас та нар нэг нэгэндээ үйлчлэхээр хөдөлмөрлөх ёстой бус уу?

19 Мөн түүнчлэн болгоогтун, хэрэв би, та нарын хаанаа болгосон тэрбээр, өөрийн өдрүүдээ та нарын үйлчлэлд зориулсан тэрбээр, мөн Бурханы үйлчлэлд байсан аваас, та нарын талархлыг хүлээх нь зохистой юм бол, Ай та нар тэнгэрлэг Хаандаа “талархах нь хичнээн их зохистой билээ!

20 Би та нарт хэлнэ, ах дүүс минь, хэрэв та нар бүхэл бодгальд чинь агуулагдаж болох бүх талархал мөн “магтаалыг илгээсэн ч, та нарыг бүтээсэн, мөн та нарыг хадгалж үлдсэн бас хамгаалсан, мөн та нарыг баясгаж, мөн та нарыг нэг нэгтэйгээ амар амгаланд амьдрахыг зөвшөөрсөн тэрхүү ^бБурханд буюу—

21 Би та нарт хэлье, хэрэв та нар эхлэлээс та нарыг бүтээсэн түүнд, мөн та нарыг өдрөөс өдөрт хадгалан хамгаалж буй, танд амьсгалыг өгснөөр, та өөрийн “хүслээр амьдарч мөн хөдөлж мөн

14a 1 Кор. 9:18.

15a су Ухамсар.

17a су Мэргэн ухаан.

б су Ах нар, Ах; Эгч.

в Мат. 25:40;

Иаков 1:27;

С ба Г 42:29–31.

су Үйлчлэл.

18a Мат. 20:26–27.

19a су Талархалтай,

Талархах, Талархал

өргөх.

20a 1 Ниф. 18:16.

б су Бурхан, Бурхан

тэргүүтэн.

21a су Сонгох эрх.

хийж болохын тулд, мөн бүр таныг нэг хормоос нөгөөд дэмжих түүнд үйлчилсэн ч — би хэлнэ, хэрэв та нар түүнд өөрсдийн бүхий л бие сэтгэлээрээ үйлчилсэн ч, та нар ^башиггүй зарц нар хэвээр байх бөлгөө.

22 Мөн болгоогтун, та нараас түүний хүсдэг бүхэн нь түүний “зарлигуудыг ^бдагах юм; мөн хэрэв та нар түүний зарлигуудыг дагавал та нар уг нутагт дэгжих болно хэмээн тэрээр та нарт амласан бөлгөө; мөн тэрээр хэлснээсээ хэзээ ч ^вухардаггүй; тиймийн тул, хэрэв та нар түүний зарлигуудыг ^вдагавал тэр та нарыг адисалж мөн та нарыг дэгжээх бөлгөө.

23 Мөн эдүгээ, юун түрүүнд, тэр та нарыг бүтээсэн, мөн та нарт амьдралыг тань хайрласан, үүний улмаас та нар түүнд өртэй болой.

24 Мөн хоёрдугаарт, тэр та нарт өөрийнхөө зарлигласныг хийхийг та нараас шаарддаг; хэрэв та нар үүнийг хийвэл оронд нь, тэрээр та нарыг тэр даруй ^вадисалдаг; мөн тиймийн тул тэрбээр та нарт төлсөн байдаг. Мөн та нар түүнд өртэй хэвээр, мөн тийм байгаа, мөн тийм байх болно, үүрд мөн үргэлж; тиймийн тул, та нар юугаар бардамнах билээ?

25 Мөн эдүгээ би асууя, та нар өөрсдийгөө юухан ч биш гэж хэлж чадах уу? Би та нарт хариулъя, Үгүй. Та нар бүр энэ газрын тоосны төдий гэж ч хэлж чадахгүй; гэсэн хэдий ч та нар энэ газрын “тоосноос ^ббүтээгдсэн; гэвч болгоогтун, энэ нь та нарыг бүтээсэн түүнд хамаарагддаг шүү дээ.

26 Мөн би, бүр би, та нар хаан хэмээн хүндэлдэг тэрбээр, би та нараас өөрсдөөс тань илүүгүй билээ; учир нь би ч түүнчлэн тоосноос буюу. Мөн миний нас өтөл гэдгийг, мөн би энэ зуурдын биеийг өөрийнх нь газар эхэд тушаахад ойрхон байгааг та нар болгоох биз ээ.

27 Тиймийн тул, та нарт би хэлсэнчлэн би та нарт үйлчилж Бурханы өмнө цэвэр ухамсартайгаар “алхсан, бүр энэ удаа ч гэсэн та нарыг энд цуглуулсан нь тэрээр надад та нарын талаар зарлигласан зүйлүүдийн дагуу Бурханаар шүүгдэхээр намайг зогсоход миний буруугүй нь тогтоогдож, мөн та нарын ^бцус над дээр ирэхгүйн тулд болой.

28 Би та нарыг өөрсдөө нэгдэн чуулах болгосон нь би өмсгөлөө та нарын цуснаас “ангжруулж болохын тулд, бараг булшиндаа доош орох болсон энэ цаг үед, би тайван доош одож болохын тулд,

21б Лук 17:7–10.

22а су Бурханы зарлигууд.
б Лев. 25:18–19;
2 Ниф. 1:9.
в С ба Г 3:1–2.

г С ба Г 14:7; 58:2–3.

24а су Адислах, Адислагдах, Адислал.
25а Эхл. 3:19;
Иаков 2:21.

б су Бүтээх, Бүтээл.

27а су Алхах, Бурхантай хамт алхах.
б Иаков 1:19.
28а Иаков 2:2.

мөн миний үхэшгүй ⁶сүнс шударга Бурханы магтаалыг дуулахад эрхэм дээдэд буй “найрал дуунд нэгдэж болохын тулд гэдгийг би та нарт хэлнэ.

29 Мөн үүнээс гадна, би та нарт үүнээс хойш та нарын багш, бас танай хаан ч байж чадахгүйг мэдэгдэж болохын тулд, би та нарыг чуулах болгосоныг би та нарт хэлнэ;

30 Учир нь бүр энэ цагт ч, та нарт ярихаар оролдож байх зуур миний бүх бие үлэмж салгалан байна; гэвч Их Эзэн Бурхан намайг дэмждэг, мөн намайг та нарт яривал зохино хэмээн зөвшөөрсөн, мөн энэ өдөр миний хүү Мозая та нарын дээрх хаан мөн захирагч гэдгийг та нарт мэдэгдвэл зохино хэмээн надад зарлигласан бөлгөө.

31 Мөн эдүгээ, ах дүүс минь, та нарыг одоог хүртэл үйлдсэн шигээ хийгээсэй хэмээнэ би. Та нар миний зарлигуудыг дагасан, мөн түүнчлэн эцгийн минь зарлигуудыг дагаж, мөн дэгжсэн, мөн дайснуудынхаа гарт оролгүй хамгаалагдсан шиг, үүнчлэн хэрэв та нар хүүгийн минь зарлигуудыг, өөрөөр хэлбэл түүгээр та нарт өгөгдөх Бурханы зарлигуудыг дагах аваас, та нар уг нутагт дэгжиж, мөн дайснууд чинь та нарыг дийлэх хүчгүй байх болно.

32 Гэвч, Ай хүмүүс минь, та нарын дунд “зөрчлүүд

байхаас, мөн миний эцэг Мозаягаар яригдсан тэр ёс бусын сүнсийг та нар дагахаар хэлбийхээс айж болгоомжил.

33 Учир нь болгоогтун, тэр сүнсийг дагахаар сонгосон түүний дээр халаг зарлагдсан; учир нь хэрэв тэрээр түүнийг дагахаар сонгож мөн нүглүүддээ үлдэж мөн үхвээс, түүнчлэн тэрбээр өөрийн бодгальд “ял уулгах болой; учир нь тэрээр өөртөө хөлс болгон ⁶үүрдийн шийтгэлийг хүлээн авна, тэрээр өөрийн мэдлэгийн эсрэг Бурханы хуулийг зөрчсөн буюу.

34 Би та нарт хэлнэ, бяцхан хүүхдүүдээс гадна та нарын дунд энэ зүйлүүдийн талаар заалгаагүй, өөрт байгаа бүхнээ мөн өөрийгөө бүхлээр нь Тэнгэрлэг Эцэгтээ өгөх мөнхийн өрөнд орсон гэдгийг мэдэхгүй; мөн түүнчлэн бүр бидний эцэг Лихай Иерусалимыг орхисон тэр цагийг хүртэл ариун бошиглогчдоор яригдсаар байсан уг бошиглолуудыг тээсэн цэдгүүдийн талаар заалгаагүй хүн байхгүй;

35 Мөн түүнчлэн, одоог хүртэл бидний эцэг өвгөдөөр яригдсаар байгаа бүгдийг тээх тэдгээрийн талаар буюу. Мөн болгоогтун, түүнчлэн, Их Эзэний тэдэнд зарлигласан түүнийг тэд ярьсан бөлгөө; гиймийн тул, тэдгээр нь шударга бас үнэн болой.

36 Мөн эдүгээ, би та нарт

хэлнэ, ах дүүс минь, та нар эдгээр бүх зүйлийг заалгасан мөн мэдсэнийхээ дараа, хэрэв та нар зөрчил гаргаж мөн яригдсаар байгаа түүний эсрэг явбаас та нар өөрсдийгөө Их Эзэний Сүнснээс холдуулна, ингэснээр та нар адислагдсан, дэгжсэн, мөн хадгалагдан үлдсэн байж болохын тулд тэрхүү мэргэн ухааны замд та нарыг удирдахад үүний орших зай та нарт байж чадахгүй биз ээ—

37 Би та нарт хэлнэ, үүнийг үйлдсэн хүмүүн, мөнхүү тэр нь Бурханы эсрэг илэрхий “тэмцлээр гарч ирэх буюу; тиймийн тул, тэр ёс бусын сүнснийг дагахаар сонгож, мөн бүх шударга ёсны дайсан болно; тиймийн тул, Их Эзэнд түүний дотор байр үгүй, учир нь тэрээр ^аариун бус дуганд үл орших бөлгөө.

38 Тиймийн тул хэрэв тэр хүмүүн ^аэс наманчилбаас, мөн Бурханы дайсан хэвээр үлдэн мөн үхвээс, тэнгэрлэг ^бшударга ёсны шаардлага түүний үхэшгүй сүнснийг өөрийнх нь ^гтэмийн амьд мэдрэмжинд сэрээж, түүнийг Их Эзэний дэргэдээс зайлсхийх болгосон тэр, мөн түүний цээжийг гэм, шаналал хийгээд тарчлалаар дүүргэх бөлгөө, түүнчлэн дөл нь үүрд

мөн үргэлж дүрэлзэх тэр, унтаршгүй гал лугаа адил байх тэр бөлгөө.

39 Мөн эдүгээ би та нарт хэлбэ, тэр хүмүүн дээр “нигүүлсэл байх эрхгүй; тиймийн тул түүний эцсийн ял нь хэзээ ч төгсөшгүй үргэлжлэх тарчлалыг амсах тэрбээр болой.

40 Ай, настай эрчүүд та нар, мөн түүнчлэн залуу эрчүүд та нар, мөн миний үгсийг ойлгож чадах бяцхан хүүхдүүд та нар, учир нь та нар ойлгож болохын тулд би та нарт тодорхой ярьсан, зөрчилд унасан тэдний аймшигт байдлыг “санахаар та нарыг сэрээсэй хэмээн залбирнам би.

41 Мөн үүнээс гадна, Бурханы зарлигуудыг дагадаг тэдний “адислагдсан мөн баярт байдлыг та нар тунгаагаасай хэмээн хүснэ би. Учир нь болгоогтун, тэд бүх зүйлд, биеийн мөн сүнсний аль алинд нь ^аадислагдсан болой; мөн хэрэв тэд төгсгөл хүртэл “итгэлтэйгээр тэвчвээс, тэгвэл тэд Бурхантай хамт хэзээ ч төгсөшгүй аз жаргалын байдалд оршиж болохын тулд тэд ‘тэнгэрт хүлээн авагдах болно. Ай санагтун, эдгээр зүйлүүд үнэнийг санагтун; учир нь Их Эзэн Бурхан үүнийг ярьсан юм.

37a Мозая 3:12;
Хил. 8:24–25.
су Эсэргүүцэл.
б Алма 7:21.

38a су Наманчлах,
Наманчлал.
б су Шударга ёс.

в су Гэм.
39a Алма 34:8–9, 15–16.
су Нигүүлсэнгүй,
Нигүүлсэл.

40a Алма 5:18.

41a 4 Ниф. 1:15–18.
су Баяр баясгалан.

б су Адислах,
Адислагдах,
Адислал.
в С ба Г 6:13.
г су Тэнгэр.

БҮЛЭГ 3

Хаан Бенжамин айлтгалаа үргэлжлүүлэв—Төгс хүчит Их Эзэн бие махбодийн асарт хүмүүний дунд тохинуулах болно—Тэрээр дэлхийн нүглүүдийг цагаатгахад арьсны сүв бүрээс нь цус шүүрэх болно—Түүнийх бол аврал эрэх цорын ганц нэр—Хүмүүн Цагаатгалаар дамжуулан эгэл хүнээ орхиж, Гэгээнтнүүд болж чаддаг—Ёс бусын тарчлал нь галан мөн хүхэрт чулуун нуур лугаа байх болно. Ойролцоогоор мэө 124 он.

Мөн түүнчлэн ах дүүс минь, би та нарын анхаарлыг хандуулъя, учир нь та нарт ярих өөр зарим зүйл надад байна; учир нь болгоогтун, ирэх түүний талаар та нарт хэлэх зүйлүүд надад байна.

2 Мөн та нарт миний хэлэх зүйлүүд Бурханы “тэнгэр элчээр надад мэдүүлэгдсэн билээ. Мөн тэрээр надад: Сэрэгтүн хэмээв; мөн би сэрсэн, мөн болгоогтун тэрбээр миний өмнө зогсов.

3 Мөн тэрээр надад хэлэв: Сэрэгтүн, тэгээд танд миний хэлэх үгсийг сонс; учир нь болгоогтун, би чамд агуу их баясгалангийн “баярт мэдээг зарлахаар ирлээ.

4 Учир нь Их Эзэн таны залбирлуудыг анхааран сонссон, мөн зөв шударга тань шүүг-

дэн тунгаагдсан билээ, мөн та баясаж болно; мөн тэд түүнчлэн баяслаар дүүргэгдэж болохын тулд та өөрийн хүмүүст зарлаж болно хэмээн танд зарлан мэдүүлэхээр намайг танд илгээсэн бөлгөө.

5 Учир нь болгоогтун, тэр цаг ирнэ, мөн энэ нь хол зайтай бус, засаглах тэр, байсан, мөн үүрд мөнхөөс үүрд мөнхөд байдаг тэр, “Төгс Хүчит Их Эзэн хүмүүний үрсийн дунд тэнгэрээс хүчтэйгээр бууж ирэх болно, мөн махбодийн ^басарт орших болно, мөн өвчтөнийг эдгээж, үхсэнийг босгон, хазгарыг алхуулж, сохрыг хараатай болгож, мөн дүлийг сонсгож, мөн зүйл бүрийн эмгэгийг анагаах зэрэг хүчит ^агайхамшгуудыг үйлдэн, хүмүүний дунд урагшлан явах болно.

6 Мөн тэрээр хүмүүний үрсийн зүрх сэтгэлд орших ёс бусын сүнснүүд, өөрөөр хэлбэл чөтгөрүүдийг “зайлуулах болно.

7 Мөн үз, тэрээр “уруу талтыг, мөн биеийн өвчин, ^бөлсгөлөн, цангаа, мөн зүдрэлийг, энэ нь үхэлд хүргэхээс бусдаар бол, бүр хүмүүний ^атэвчиж чадахаас илүүг тэвчих болно; учир нь болгоогтун, арьсных нь сүв бүрээс ^гцус шүүрэх болно, өөрийнхөө хүмүүсийн ёс бус мөн жигшүүрт хэргүүдийн төлөөх

3 *2a* су Тэнгэр элчүүд.
3*a* Лук 2:10–11.
5*a* су Иехова.
б Мозая 7:27;
Алма 7:9–13.

в Мат. 4:23–24;
Үйлс 2:22;
1 Ниф. 11:31.
су Гайхамшиг.
6*a* Марк 1:32–34.

7*a* су Уруу татах, Уруу таталт.
б Мат. 4:1–2.
в С ба Г 19:15–18.
г Лук 22:44.

түүний ^oтарчлал ийм агуу байх болно.

8 Мөн тэрээр “Есүс Христ, ^бБурханы Хүү, ^ттэнгэр ба газрын Эцэг, эхлэлээс бүх зүйлийг Бүтээгч хэмээн нэрлэгдэх болно; мөн түүний ^{эх} ^oМариа гэгдэх болно.

9 Мөн үз, тэрээр өөрийнхөндөө ирнэ, “аврал нь мөн түүний нэрэнд итгэх ^битгэлээр хүмүүний үрсэд ирж болохын тулд буюу; мөн бүр энэ бүгдийн дараа ч тэд түүнийг хүн хэмээн бодож, мөн түүнд ^чөтгөр шүглэсэн хэмээн хэлж, мөн түүнийг ^тташуурдаж, мөн түүнийг ^цовдлох болно.

10 Мөн тэр “гурав дахь өдөр нь нас барагсдаас ^ббосох болно; мөн болгоогтун, тэрээр дэлхийг ^шшүүхээр зогсоно; мөн болгоогтун, хүмүүний үрсийн дээр зөв шударга шүүлт ирж болохын тулд эдгээр бүх зүйл үйлдэгдэх болно.

11 Учир нь болгоогтун, мөн түүнчлэн түүний “цус, Адамын зөрчлөөр ^бунагаагдсан тэд, өөрсдийн талаарх Бурха-

ны тааллыг мэдэлгүйгээр нас барсан тэд, өөрөөр хэлбэл “үл мэдэн нүгэл үйлдсэн тэдний нүглүүдийг ‘цагаатгах болно.

12 Гэвч Бурханы эсрэг “тэмцэж буйгаа мэдэх түүнд халаг, халаг! Учир нь наманчлал мөн ^бИх Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр дамжихаас бусдаар бол эдний хэний нь ч дээр аврал ирэх нь үгүй.

13 Мөн түүгээр хэн боловч Христ ирэх ёстой гэдэгт итгэж, мөнхүү тэд нүглүүдийнхээ “ангижралыг хүлээн авч, мөн бүр тэрээр аль хэдийн тэдний дунд ирсэн ^бмэт тийм үлэмж агуу баяслаар баярлаж болохын тул эдгээр зүйлийг үндэстэн, ястан, мөн хэлтэн бүрд зарлуулахаар Их Эзэн Бурхан ариун бошиглогчдоо хүмүүний үрсийн дунд илгээсэн бөлгөө.

14 Гэвч Их Эзэн Бурхан түүний хүмүүс хөшүүн хүзүүтэй хүмүүс байсныг харсан, мөн тэрээр тэдний дээр нэгэн хуулийг, бүр “Мосегийн хуулийг тогтоосон билээ.

15 Мөн олон тэмдэг, мөн гайхамшгууд, мөн “бэлэгдлүүд,

7d Иса. 53:4–5.

8a су Бурхан, Бурхан тэргүүтэн —Хүү Бурхан.

б Алма 7:10.

в Хил. 14:12;

3 Ниф. 9:15.

г Мат. 1:16;

1 Ниф. 11:14–21.

d су Мариа, Есүсийн эх.

9a су Аврал.

б су Итгэл.

в Иохан 8:48.

г Марк 15:15.

d Лук 18:33;

1 Ниф. 19:10;

2 Ниф. 10:3.

су Цовдлуулалт.

10a Мат. 16:21;

2 Ниф. 25:13;

Хил. 14:20–27.

б су Амилуулалт.

в су Шүүх, Шүүлт.

11a су Цус.

б су Адам Ева хоёрын Уналт.

в 2 Ниф. 9:25–26.

г су Цагаатгах,

Цагаатгал.

12a Мозая 2:36–38;

Хил. 8:25.

су Эсэргүүцэл.

б су Их Эзэн.

13a су Нүглүүдийн

ангижрал.

б 2 Ниф. 25:24–27;

Жером 1:11.

14a су Мосегийн Хууль.

15a су Есүс Христ—

Есүс Христийн

бэлэгдэл болон хэв

шинж.

мөн дүрслэлүүдийг тэрээр тэдэнд үзүүлсэн, өөрийн ирэлтийн талаар буюу; мөн түүнчлэн ариун бошиглогчид түүний ирэлтийн талаар тэдэнд ярьсан бөлгөө; тийм хэдий ч тэд зүрх сэтгэлээ хатууруулж, мөн ⁶Мосегийн хууль түүний цусны цагаатгалаар бус аваас огтхон ч тус болохгүйг ойлгосонгүй.

16 Мөн бяцхан “хүүхдүүд нүгэл үйлдэх боломжтой байсан бол, тэд аврагдаж чадахгүй байхсан; гэвч тэд ⁶адислагдсаныг би та нарт хэлье; учир нь болгоогтун, Адамаар, өөрөөр хэлбэл төрөлх чанараараа, тэд унасан шиг, тэрчлэн Христийн цус тэдний нүглүүдийг цагаатгасан бөлгөө.

17 Мөн үүнээс гадна, би та нарт хэлнэ, түүгээр хүмүүний үрсэд “аврал ирж чадах тэр ⁶нэгээхэн ч өөр нэр өгөгдөхгүй, басхүү нэгээхэн ч өөр зам, мөн нэгээхэн ч арга үгүй бөгөөд зөвхөн Төгс Хүчит Их Эзэн, “Христийн нэрээр мөн энэ нэр дээр буюу.

18 Учир нь болгоогтун тэрээр шүүнэ, мөн түүний шүүлт шударга; мөн нялхдаа нас барах тэрхүү нялхас мөхөхгүй; гэвч тэд өөрсдийгөө даруусган мөн бяцхан хүүхдүүд

лугаа адил “болж, мөн Төгс Хүчит Их Эзэн, Христийн ⁶цагаатгалын цусаар мөн энэ цусанд аврал байсан, мөн байгаа, мөн байх болно гэдэгт итгэхгүй аваас хүмүүн өөрсдийн бодгалиудад зүхлийг уух болно.

19 Учир нь “эгэл хүн бол Бурханы дайсан, мөн Адамын ⁶уналтаас тийм байсаар ирсэн, мөн тэрээр Ариун ⁶Сүнсний таталтанд ‘автагдан, эгэл хүмүүнээ орхиж мөн Их Эзэн Христийн цагаатгалаар ⁹гэгээнтэн болж, ‘хүүхэд шиг хүлцэнгүй, номхон, даруухан, тэвчээртэй, хайраар дүүрэн, бүр хүүхэд эцэгтээ захирагдаг шиг Их Эзэн түүн дээр ноогдуулах бүх зүйлийг хүлцэхэд бэлэн бус аваас үүрд мөн үргэлж тийм байх болно.

20 Мөн үүнээс гадна, би та нарт хэлнэ, нэгэн Аврагчийн талаарх “мэдлэг бүх ⁶үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс бүрийн дунд тархах тэр цаг ирэх болно.

21 Мөн болгоогтун, тэр цаг ирэхэд бяцхан хүүхдүүдээс бусад нь, зөвхөн Төгс Хүчит Их Эзэний нэрэнд итгэх итгэл мөн наманчлалаар бус аваас хэн ч Бурханы өмнө “буруугүй нь тогтоогдохгүй.

15б Мозая 13:27–32.

16а су Хүүхэд,
Хүүхдүүд.
б Моро. 8:8–9.

17а су Аврал.
б Үйлс 4:10–12;
2 Ниф. 31:21.

в су Есүс Христ—
Өөрсөд дээрээ
Есүс Христийн

нэрийг авах.

18а Мозая 4:2;
Хил. 5:9.
б Мат. 18:3.

19а 1 Кор. 2:11–14;
Мозая 16:2–3.
су Эгэл хүн.

б су Адам Ева хоёрын
Уналт.
в Моро. 10:4–5.

су Ариун Сүнс.

г Шаст. дэд 30:8.

д су Гэгээнтэн.

е 3 Ниф. 9:22.

20а С ба Г 3:16.

б су Номлолын ажил.

21а су Хариуцах,
Хариуцлага,
Хариуцлагатай.

22 Мөн бүр та өөрийн хүмүүст Их Эзэн Бурхан чинь танд зарлигласан зүйлийг заасан байх бүр энэ цагт ч, тэр үед ч Бурханы мэлмийд тэдний буруугүй нь дахин тогтоогдохгүй, зөвхөн танд ярьсан миний үгсийн дагуу буюу.

23 Мөн эдүгээ Их Эзэн Бурхан надад зарлигласан үгсийг би ярилаа.

24 Мөн Их Эзэн ийн хэлдэг: Тэдгээр нь энэ хүмүүсийн эсрэг илэрхий гэрчлэл болон шүүлтийн өдөр зогсох болно; ингэснээр тэд, хүн бүр өөр өөрийн үйлүүдийн дагуу, тэд сайнаараа эс бөгөөс хилэнцэтээрээ шүүгдэх болно.

25 Мөн хэрэв тэд хилэнцэт аваас тэд Их Эзэний дэргэдээс зайлан, тэд дахин хэзээ ч буцаж ирж үл чадах “зовлонгийн мөн төгсгөлгүй тарчлалын байдалд ороход хүргэх, өөрсдийнхөө гэм болоод жигшүүрт хэргүүдийн аймшигт ^бтөсөөлөлд оногдох болно; тиймийн тул тэд бодгалиудаа зүхлийг уух бөлгөө.

26 Тиймийн тул, тэр хориглогдсон “жимснээс хүртсэн учир ^аАдам унах ёстойг шударга ёс цуцалж чадаагүйн адил, тэрчлэн шударга ёс нь тэдний уух ёстойг хэлтрүүлж үл чадах, Бурханы хилэнгийн аяганаас тэд уусан байна;

тиймийн тул, тэдний дээр “нигүүлсэл дахин байх эрхтэй байж чадахгүй бөлгөө.

27 Мөн тэдний “тарчлал дөл унтраагдашгүй, мөн утаа нь үргэлж мөн үүрд уугих тэрхүү ^бгалан мөн хүхэрт чулуун нуур лугаа адил байх болно. Тийн Их Эзэн надад зарлигласан билээ. Амен.

БҮЛЭГ 4

Хаан Бенжамин айлтгалаа үргэлжлүүлэв— Аврал цагаатгалын улмаас ирдэг— Аврагдахын тулд Бурханд итгэгтүн— Итгэл дүүрэн байдлаар нүглүүдийнхээ ангижралыг хадгалагтун— Хөрөнгөнөөсөө ядуустай хуваалц— Бүх зүйлийг мэргэн ухаанд мөн эмх цэгцэнд үйлдэгтүн. Ойролцоогоор мээ 124 он.

Мөн эдүгээ, улиран тохиох дор хаан Бенжамин Их Эзэний тэнгэр элчээр түүнд хүргэгдсэн үгсийг ярихаа төгсгөл болгоод, эргэн тойрондоо байх хүмүүсийн зүг харц бэлчээж, мөн тэдний дээр ирсэн Их Эзэнээс “эмээх айдсын учир тэд газарт унасан байхыг болгоов.

2 Мөн тэд өөрсдийгөө “зуурдын байдалд буйгаа бүр газрын тоосноос ч ^бөчүүхнээ төсөөлсөн ажгуу. Мөн тэд бүгд нэгэн дуугаар чанга хашгирч,

25a Морм. 8:38.

б Алма 5:18; 12:14–15.

26a Эхл. 3:1–12;

2 Ниф. 2:15–19;

Алма 12:21–23.

б Морм. 9:12.

в су Нигүүлсэнгүй,

Нигүүлсэл.

27a су Гэм.

б 2 Ниф. 9:16;

Иаков 6:10;

С ба Г 76:36.

4 1a су Айдас.

2a су Тачаангуй,

Зуурдын.

б Хил. 12:7–8.

хэлсэн нь: Ай нигүүлсэж хайрла, мөн бид нүглүүддээ өршөөлийг хүлээж авч болохын тулд мөн зүрх сэтгэл маань ариуссан байж болохын тулд Христийн цагаатгагч “цусыг нөлөөлүүлээч; учир нь бид Есүс Христэд, тэнгэр ба газар, мөн бүх зүйлийг бүтээсэн Бурханы Хүүд хүмүүний үрсийн дунд доош ирэх түүнд итгэдэг.

3 Мөнхүү улиран тохиох дор тэд эдгээр үгсийг ярьсны дараа Их Эзэний Сүнс тэдний дээр ирж, мөн тэд нүглүүдийнхээ “ангижралыг хүлээн авч, улмаар тэд ^бухамсрын амар амгаланг хүлээн авсан учир, мөн тэд баяр хөөрөөр дүүргэгдсэн байв, хаан Бенжамин тэдэнд ярьсан үгсийн дагуу, ирэх ёстой Есүс Христэд итгэх үлэмж ^иитгэл тэдэнд байсны учир бөлгөө.

4 Мөн хаан Бенжамин дахин амаа нээж мөн тэдэнд ярьж эхлэв, хэлсэн нь: Нөхөд минь бас ах дүүс минь, миний үндэстэн мөн хүмүүс минь, би та нарын анхаарлыг дахин хүсье, та нарт миний ярих үгсийн үлдсэнийг та нар сонсож мөн ойлгож болохын тулд бөлгөө.

5 Учир нь болгоогтун, хэрэв “Бурханы сайн сайхны мэдлэг энэ цагт та нарын юу ч

бишийг мөн та нарын ашиггүй хийгээд унасан байдлын мэдрэмжид сэрээсэн бол—

6 Би та нарт хэлнэ, хэрэв Бурханы сайн сайхан, мөн түүний зүйрлэшгүй хүч, мөн түүний мэргэн ухаан, мөн түүний тэвчээр, мөн түүний хүмүүний үрсэд хандсан тэсвэрийн тухай; мөн түүнчлэн, түүгээр Их Эзэнд “найдлага тавьсан мөн түүний зарлигуудыг дагахдаа хичээнгүй байсан, мөн үргэлж, бүр өөрийн амьдралын, би зуурдын биеийн амьдралыг хэлж байна, төгсгөл хүртэл итгэлтэй байсан түүнд аврал ирж болохын тулд, ^ддэлхийн үүслээс бэлтгэгдсэн ^ццагаатгалын тухай ^ммэдлэгт ирсэн бол—

7 Энэ нь Адамын “уналтаас хойш байсан, эсвээс байгаа, эсвээс бүр энэ дэлхийн төгсгөлийг хүртэл байх, бүх хүн төрөлхтөнд зориулж дэлхийн үүслээс бэлтгэгдсэн тэрхүү цагаатгалаар авралыг хүлээн авах тэр хүн бол энэ юм гэдгийг би хэлнэ.

8 Мөн энэ нь аврал хэрхэн ирэхийн арга билээ. Мөн энд яригдсанаас ^өөөр аврал гэж үгүй; бас та нарт миний ярьсан тэр нөхцлүүдээс өөр хүмүүн аврагдаж болох ямар ч нөхцөлүүд үгүй.

9 Бурханд итгэ; тэр байдагт

2в Мозая 3:18; Хил. 5:9.

г су Бүтээх, Бүтээл.

3а су Нүглүүдийн ангижрал.

б су Ухамсар.

в су Итгэл.

5а Моце 1:10.

6а Дуул. 36:7;

2 Ниф. 22:2;

Хил. 12:1.

су Итгэл.

б Мозая 15:19.

в су Цагаатгах,

Цагаатгал.

г су Бурхан, Бурхан тэргүүтэн.

7а су Адам Ева хоёрын Уналт.

8а Үйлс 4:12;

2 Ниф. 31:21;

Мозая 3:17.

итгэ, мөн тэр, тэнгэрт болон газарт аль алин дээрх бүх зүйлийг бүтээсэнд итгэ; тэр бол тэнгэрт мөн газарт аль алинд нь бүх “мэргэн ухааныг, мөн бүх хүч чадлыг эзэмшигч гэдэгт итгэ; Их Эзэний ухаарч чадах тэр бүх зүйлийг хүмүүн ^бухаардаггүйд итгэ.

10 Мөн үүнчлэн, та нар нүглүүдээ “наманчилж мөн тэдгээрийг орхих ёстой, мөн өөрсдийгөө Бурханы өмнө даруусгах ёстойд итгэ; мөн тэрээр та нарыг ^буучлаасай хэмээн чин зүрхнээсээ гуй; мөн эдүгээ, хэрэв та нар эдгээр бүх зүйлд ^аитгэвэл тэдгээрийг өөрсдөө ^гүйлдэхэд анхаарагтун.

11 Мөн би урьд хэлснийхээ адил дахин би та нарт хэлье, та нар Бурханы алдар суугийн мэдлэгт ирсэн шиг, эсвээс хэрэв та нар түүний сайн сайхныг мэдэж мөн түүний хайрыг ^аамталсан, мөн та нарын бодгалиудад үлэмж агуу баясал авчрах, нүглүүдийнхээ ^бангижралыг хүлээн авсан бол, тэрчлэн Бурханы агуу ихийг, мөн өөрсдийнхөө ^аюу ч биш болохыг, мөн түүний ^гсайн сайхан хийгээд зохисгүй бүтээлүүд болох та нарт хандсан тэсвэрийг нь та нар үргэлж дурсан санаасай

хэмээнэ би, мөн та нар өөрсдийгөө бүр ^даруу байдлын гүнд даруусгаж, Их Эзэний нэрийг өдөр тутам ^едуудан, мөн тэнгэр элчийн амаар яригдсан тэрхүү ирэх зүйлд итгэх сүсэг бишрэлд гуйвшгүйгээр зогсоой хэмээнэ.

12 Мөн болгоогтун, хэрэв та нар үүнийг хийвээс та нар үргэлж баясна, мөн Бурханы ^ахайраар дүүргэгдэж, мөн нүглүүдийнхээ ангижралыг үргэлж ^бхадгалах болно хэмээн би та нарт хэлнэ; мөн та нарыг бүтээсэн түүний алдар суугийн мэдлэгт, эсвээс шударга бөгөөд үнэн болох түүний мэдлэгт та нар өсөх болно.

13 Мөн бие биенээ гомдоох биш, харин ^аамар амгалангаар амьдрах, мөн хүн бүрд өөрийн өр төлөөсийн дагуу төлөх санаа та нарт бий болно.

14 Мөн та нар ^ахүүхдүүдээ өлсгөлөн, эсвээс нүцгэн явахыг тэвчихгүй болой; бас тэд Бурханы хуулиудыг зөрчихийг, мөн нэг нэгэнтэйгээ ^ббайлдан мөн тэмцэх, мөн нүглийн эзэн болох, өөрөөр хэлбэл бидний эцэг өвгөдийн ярьдаг байсан муу ёрын сүнс чөтгөрт үйлчлэхийг зөвшөөрөхгүй, учир нь тэр бол бүх зөв шударгын дайсан билээ.

9а Ром 11:33–34;
Иаков 4:8–13.

б Иса. 55:9.

10а су Наманчлах,
Наманчлал.

б С ба Г 61:2.

в Мат. 7:24–27.

г 2 Ниф. 31:19–21.

11а Алма 36:24–26.

б су Нүглүүдийн
ангижрал.

в Мосе 1:10.

г Ег. 34:6; Моро. 8:3.

д су Даруу, Даруу
байдал.

е су Залбирал.

12а су Хайр.

б Мозая 4:26;

Алма 4:13–14;
5:26–35;

С ба Г 20:31–34.

13а су Амар амгаланг
тогтоогч.

14а 1 Тим. 5:8;

С ба Г 83:4.

б су Уруу таталт.

15 Харин үнэний мөн чанд байдлын замуудаар “алхахыг та нар тэдэнд^в заах болно; бие биенээ “хайрлах, мөн ндээ үйлчлэхийг та нар тэдэнд заах болно.

16 Мөн түүнчлэн, та нарын халамжаар гачигдах тэднийг та нар өөрсдөө “халамжлах болно; та нар өөрсдийн хөрөнгөнөөс гачигдаж байгаа түүнд өгөх болно; мөн та нар гуйлгачны хүсэлтийг хоосон буцааж^б тэвчихгүй, мөн түүнийг мөхөл уруу нь хөөхгүй байх болно.

17 Магад та нар “хэлнэ: Хүн зовлонгоо өөр дээрээ авчирдаг; тиймийн тул би гараа татаж, мөн түүнд хүнснээсээ өгөхгүй, бас тэрбээр зовохгүй байж болохын тулд хөрөнгөнөөсөө ч түүнд хүртээхгүй, учир нь түүний шийтгэлүүд шударга—

18 Гэвч би та нарт хэлнэ, Ай хүмүүн, үүнийг хийх хэн боловч, мөнхүү тэр нь наманчлах агуу шалтгаантай байдаг; мөн тэр хийсэн зүйлээ наманчлахгүй бол тэрээр үүрд мөхөж мөн Бурханы хаант улсад хамаагүй байх болно.

19 Учир нь болгоогтун, бид бүгд гуйлгачид бус уу? Бид бүгд нэгэн адил Бие, бүр Бурханаас хамаардаг, бидэнд байгаа бүх хөрөнгө, хоол хүнс

мөн хувцас хунар, мөн алт, мөн мөнгө, мөн бидэнд байгаа төрөл бүрийн бүх баялгууд түүнээс бус гэж үү?

20 Мөн болгоогтун, бүр энэ цагт, та нар түүний нэрийг дуудаж, мөн нүглүүддээ ангижралыг гуйж байна. Мөн тэрээр хоосон гуйхыг та нарт зөвшөөрсөн үү? Үгүй; тэр өөрийн Сүнсийг та нарын дээр цугтаж, мөн та нарын зүрх сэтгэл “баяраар дүүргэгдэхээр болгож, мөн та нар ийм үлэмжийн агуу баяслаа илэрхийлэх арга олж чадахгүйд хүргэн та нарын амыг хамхисан байхаар болгосон буюу.

21 Мөн эдүгээ, хэрэв Бурхан, та нарыг бүтээсэн тэрбээр, та нарын амьдрал мөн та нарт байгаа бүхэн, та нар бүхлээрээ хамаарах тэрбээр, та нарын итгэлтэйгээр хүлээн авах болно гэдэгт итгэн гуйсан зөв болох юуг ч та нарт хайрладаг бол, Ай тэгвэл, та нар өөрсдөдөө байгаа хөрөнгөнөөс нэг нэгэнтэйгээ “хуваалцах нь хичнээн их зохистой билээ.

22 Мөн тэрээр мөхөхгүйн тул чамд хандан хөрөнгөнөөс чинь гуйх хүнийг та нар “шүүн, мөн түүнийг буруутгах аваас, та нарт бус, харин та нарын амьдрал ч түүнчлэн түүнд хамаарагдах тэр Бурханд харъяалагдах эд

15а су Аллах,
Бурхантай хамт
аллах.
б С ба Г 68:25–28;
Моце 6:58.
су Заах, Багш.

в Мозая 18:21.
16а су Энэрэл;
Үйлчлэл.
б Дэд хууль 15:7–11;
Сур. үгс 21:13;
Иса. 10:1–2.

17а Сур. үгс 17:5.
20а су Баяр баясгалан.
21а су Үйлчлэл;
Халамж.
22а Мат. 7:1–2;
Иохан 7:24.

хөрөнгөө ⁶харамласны улмаас хүртэх та нарын буруушаалт хэр зэрэг илүү шуударга байх билээ; гэсэн хэдий ч, та нар гуйлга гуйх нь, бас хийсэн тэр зүйлээ наманчлах нь үгүй бөлгөө.

23 Би та нарт хэлнэ, тэр хүнд халаг, учир нь түүний хөрөнгө түүнтэй хамт мөхөх болно; мөн эдүгээ, би эдгээр зүйлийг энэ дэлхийн зүйлүүдэд хамаарагдах зүйлээр “баян тэдэнд хэлж байна.

24 Мөн үүнчлэн, би ядууст, эд хөрөнгөгүй боловч шар наран бор хоногийг хоолтой өнгөрөөх та нарт хэлнэ; та нарт байгаагүйн учир гуйлгачныг буцаах та нарыг бүгдийг чинь би хэлж байна; та нарыг зүрх сэтгэлдээ ингэж хэлээсэй хэмээнэ би: Надад байгаагүй учраас би өгөөгүй, харин хэрэв надад байсан бол би “өгөх байсан.

25 Мөн эдүгээ, хэрэв та нар зүрх сэтгэлдээ ийн хэлбэл та нар гэмгүй үлдэнэ, эс тэгвэл та нар “буруушаагдана; мөн та нар хүлээн аваагүй тэр юманд шунасны учир та нарын авах буруушаалт шуударга байх буюу.

26 Мөн эдүгээ, та нарт мийн ярьсан эдгээр зүйлүүдийн учир — өөрөөр хэлбэл, та нар Бурханы өмнө “гэмгүйгээр алхаж болохын тулд өдрөөс өдөрт нүглүүдийнхээ

ангижралыг хадгалан үлдэхийн төлөө — та нар хүн бүр байгаагийнхаа хэрээр ⁶ядуустай хөрөнгөө “хуваалцаасай хэмээнэ би, ‘өлссөнийг хоолох, нүцгэнийг хувцаслах, өвчтэйд очиж мөн сүнсийг нь мөн биеийг нь ч аль алиныг нь, хүссэнийх нь дагуу тэднийг асрах зэрэг болой.

27 Мөн эдгээр бүх зүйл мэргэн ухаанд мөн эмх цэгцэнд хийгддэг байхыг мэдэгтүн; учир нь хүн өөрт нь буй хүчнээс илүү “хурдан гуйх шаардлагагүй. Мөн үүнчлэн, тэрээр хичээнгүй байх шаардлагатай, тэгснээр тэр шагналыг хожиж болохын тулд бөлгөө; тиймийн тул бүх зүйл эмх цэгцэнд хийгдэх ёстой.

28 Мөн та нарын дунд хөршөөсөө зээлсэн хэн боловч зээлсэн тэр зүйлээ тохирсны дагуу эргүүлж өгөх ёстой, эсвээс та нүгэл үйлдэх болно; мөн магад та өөрийн хөршийг түүнчлэн нүгэл үйлдэхэд хүргэх вий гэдгийг та нар санаасай хэмээнэ би.

29 Мөн эцэст нь, та нар тэгснээр нүгэл үйлдэж болох зүйлийг бүгдийг би та нарт хэлж чадахгүй; учир нь маш олон янзын зам мөн аргууд бий, бүр тэдгээрийг би тоолж чадахааргүй тийм олон бөлгөө.

30 Гэвч өдий зэргийг би та

22б 1 Иохан 3:17.

23а С ба Г 56:16.

24а Марк 12:44.

25а С ба Г 56:17.

26а су Аллах, Бурхантай

хамт алхах.

б Иаков 2:17–19.

в Зех. 7:10; Алма 1:27.

су Өглөг, Өглөг

өгөх.

г Иса. 58:10–11;

С ба Г 104:17–18.

27а С ба Г 10:4.

нарт хэлж чадна, хэрэв та нар өөрсдийгөө, мөн “бодлуудаа, мөн ^бүгсээ, мөн үйлүүдээ “хянаж, мөн Бурханы зарлигуудыг мөрдөж, бас Их Эзэний маань ирэлтийн талаар сонссон түүндээ үргэлж итгэлтэй байж, бүр амьдралынхаа эцсийг хүртэл ингэхгүй аваас, та нар мөхөх ёстой болно. Мөн эдүгээ, Ай хүмүүн, санагтун, мөн бүү мөхөгтүн.

БҮЛЭГ 5

Гэгээнтнүүд итгэлийнхээ дагуу Христийн хөвгүүд, охид болцгоов—Тэд тийн Христийн нэрээр нэрлэгдэв—Сайн үйлүүдэд тогтвортой мөн гуйвшгүй байхыг хаан Бенжамин тэдэнд ухуулав. Ойролцоогоор мээ 124 он.

Мөн эдүгээ, улиран тохиох дор хаан Бенжамин өөрийн хүмүүст тийн яриад, тэд өөрсдөд нь түүний ярьсан үгэнд итгэсэн эсэхийг мэдэхийг тэрээр хүсэн тэдний дунд илгээсэн бөлгөө.

2 Мөн тэд бүгд нэгэн дуугаар хашгирч, өгүүлсэн нь: Тийм ээ, бидэнд ярьсан тэр бүх үгсэд тань бид итгэнэ; мөн түүнчлэн, бидэнд “хилэнцийг үйлдэх хүслийг үгүй болгох, харин үргэлж сайныг хийх болгон, бидэнд, өөрөөр хэлбэл бидний зүрх сэтгэлд хүчирхэг ^бөөрчлөлтийг

үйлдсэн Төгс Хүчит Их Эзэний Сүнсний учир тэдгээрийн гарцаагүйг мөн үнэнийг бид мэднэ.

3 Мөн бид, өөрсдөө, түүнчлэн, Бурханы хэмжээлшгүй сайн сайхнаар, мөн түүний Сүнсний илэрхийнлүүдээр, ирэх тэр зүйлүүдийн агуу үзэгдлүүдийг хүлээн авдаг; мөн энэ нь зохист байсан бол бид бүх зүйлийн тухай бошиглож чадах сан билээ.

4 Мөн биднийг ийм үлэмжийн агуу баяраар баярлах болгосон нь, энэ агуу мэдлэгт биднийг авчирсан нь манай хааны ярьсан зүйлүүдэд бидний хадгалах тэрхүү итгэл бөлгөө.

5 Мөн бид өөрсдийгөө “тэнгэр элчүүдээр яригдсан шиг ^бтөгсгөлгүй зовлонд авчрахгүй байж болохын тулд, бид Бурханы хилэнгийн аяганаас уухгүй байж болохын тулд бид үлдсэн бүх өдрүүддээ бидэнд түүний зарлиглах, бүх зүйлд, түүний зарлигуудад дуулгавартай байж, Бурхантайгаа түүний тааллыг гүйцэлдүүлэх ^бгэрээ хийхэд бэлэн байна.

6 Мөн эдүгээ, эдгээр нь хаан Бенжамин тэднээс хүссэн үгс; мөн тиймийн тул тэрээр тэдэнд хэлэв: Та нар миний хүссэн үгсийг ярилаа; мөн та нарын хийсэн тэрхүү гэрээ бол зөв шударга гэрээ болой.

30a Марк 7:18–23.
су Бодлууд.
б Мат. 15:18–20.
су Бүдүүлэг үг
хэллэг.

в Алма 12:14.
су Харах, Харуул.
5 2a Алма 19:33.
б Алма 5:14.
су Дахин төрөх,

Бурханаас төрөх.
5a Мозая 3:2.
б Мозая 3:25–27.
в Мозая 18:10.

7 Мөн эдүгээ, та нарын хийсэн гэрээний учир та нар Христийн “хүүхдүүд, түүний хөвгүүд, мөн түүний охид гэж нэрлэгдэх болно; учир нь болгоогтун, энэ өдөр тэрээр та нарыг оюун санаагаар тань ^бтөрүүллээ; учир нь та нарын ^взүрх сэтгэл түүний нэрэнд итгэх итгэлээр өөрчлөгдсөн хэмээн та нар хэллээ; тиймийн тул, та нар түүнээс ^гтөрсөн мөн түүний ^дхөвгүүд мөн түүний охид болсон бөлгөө.

8 Мөн энэ нэрэн дор та нар “эрх чөлөөтэй болгогдсон, мөн үүнээс ^бөөр та нар чөлөөт болгогдож чадах нэр үгүй билээ. Түүгээр аврал ирэх үүнээс өөр “нэр гэж үгүй; тиймийн тул, та нарыг, амьдралынхаа төгсгөлийг хүртэл дуулгавартай байхаар Бурхантай гэрээнд орсон та нар бүгдийг Христийн нэрийг өөрсөд дээрээ ^гхүлээн аваасай хэмээнэ.

9 Мөнхүү улиран тохиох дор үүнийг хийсэн нь Бурханы баруун гар талд олдох болно, учир нь тэрээр өөрийн нэрлэгдсэн нэрээ мэдэх болно; учир нь тэрээр Христийн нэрээр нэрлэгдэх болно.

10 Мөнхүү улиран тохиох дор, Христийн нэрийг өөр дээрээ авахгүй хэн боловч

“өөр ямар нэгэн нэрээр нэрлэгдэх ёстой; тиймийн тул, тэрээр Бурханы ^бзүүн гар талд өөрийгөө олох буую.

11 Мөн энэ бол та нарт миний өгвөл зохино гэсэн, зөрчлөөс бусдаар бол хэзээ ч арилгагдахгүй “нэр гэдгийг түүнчлэн та нар санаасай хэмээнэ би; тиймийн тул, уг нэр та нарын зүрх сэтгэлээс арилгагдахгүйн тулд, зөрчил гаргахгүй байхад анхаарагтун.

12 Би та нарт хэлнэ, та нар Бурханы зүүн гар талд олдохгүйн тулд, харин та нар өөрсдийн дуудагдах дуу хоолойг, мөн түүнчлэн та нарыг дуудах нэрийг сонсож бас мэдэхийн тулд уг нэрийг зүрх сэтгэлдээ үргэлж бичээстэй нь “хадгалахыг та нар санаасай хэмээнэ би.

13 Учир нь өөрийн үйлчилж байгаагүй, өөрийн танихгүй нэгэн болох, мөн зүрх сэтгэлийн бодол хийгээд зорилтоос нь хол байх эзнээ хүн хэрхэн “мэдэх билээ?

14 Мөн түүнчлэн, хүн хөршид нь харъяалагдах илжгийг авч өөртөө үлдээх үү? Би та нарт хэлнэ, Үгүй; тэрээр түүнийг сүргийнхээ дунд тэжээхийг ч зөвшөөрөхгүй, харин түүнийг гадагш тууж,

7a Мозая 27:24–26;
Моце 6:64–68.
су Бурханы хөвгүүд охид.
б су Төрсөн.
в су Зүрх сэтгэл.
г Мозая 15:10–11.
су Дахин төрөх,
Бурханаас төрөх.

д С ба Г 11:30.
8a Ром 6:18;
Гал. 5:1;
Хил. 14:30.
б Үйлс 4:10, 12;
Алма 21:9.
в Мозая 26:18.
г Үйлс 11:26;
Алма 46:15.

10a Алма 5:38–39.
б Мат. 25:33.
11a Мозая 1:11–12.
су Есүс Христ—
Өөрсөд дээрээ Есүс Христийн нэрийг авах.
12a С ба Г 18:23–25.
13a Мозая 26:24–27.

зайлуулах болно. Би та нарт хэлнэ, энэ нь хэрэв та нар нэрлэгдэх нэрээ эс мэдвээс та нарын хувьд ч энэчлэн байх болно.

15 Тиймийн тул, тэнгэр ба газарт орших бүх зүйлийг “бүтээсэн, бүхний дээрх Бурхан болох түүний мэргэн ухаан хийгээд хүч, мөн шударга ёс, мөн нигүүлслээр та нар үүрдийн аврал хийгээд мөнх амьдралыг авч болохын тулд, та нар тэнгэрт авчрагдаж болохын тулд, Христ, Төгс Хүчит Их Эзэн Бурхан та нарыг өөрийнх байлгахаар ^блацдаж болохын тулд, та нарыг хичээнгүй мөн гуйвшгүй байж, сайн үйлүүдээр үргэлж бялхаасай хэмээнэ би. Амен.

БҮЛЭГ 6

Хаан Бенжамин хүмүүсийн нэрийг цэдэглэж мөн тэдэнд сургах санваартнуудыг томилов—Мозая зөв шударга хааны ёсоор засаглав. Ойролцоогоор мээ 124–121 он.

Мөн эдүгээ, хаан Бенжамин хүмүүст ярьж дууссанахаа дараа, зарлигуудыг нь дагахаар Бурхантай гэрээнд орсон тэд бүгдийн нэрсийг тэрээр “авбал зохино хэмээн бодов.

2 Мөнхүү улиран тохиох дор бяцхан хүүхдүүдээс бусад

нь, гэрээнд орж мөн Христийн нэрийг өөрсдийн дээр аваагүй нэгээхэн ч бодгаль байсангүй.

3 Мөн түүнчлэн, улиран тохиох дор хаан Бенжамин эдгээр бүх зүйлийн төгсгөлийг үйлдэж, мөн “хүү Мозаягаа өөрийн хүмүүсийн дээр захирагч бөгөөд хаан байхаар томилон адисалж, мөн түүнд хаант улсын талаарх бүх хариуцлагыг өгөв, мөн түүнчлэн тэд Бурханы зарлигуудыг сонсож бас мэдэж болох бөгөөд тэднийг өөрсдийнх нь өргөсөн ^бтангаргийг санахад өдөөн хатгахын тулд хүмүүст ^ссургах ^ссанваартнуудыг томилоод, тэрээр олон ардыг тарааж мөн тэд, хүн бүр, өөр өөрийн гэр бүлд, гэртээ буцацгаав.

4 Мөн “Мозая эцгийнхээ оронд засаглаж эхлэв. Мөн тэрээр гучин насандаа засаглаж эхэлсэн болой, бүхэлдээ Лихай Иерусалимыг орхисон ^бцагаас ойролцоогоор дөрвөн зуун далан зургаан жил болжээ.

5 Мөн хаан Бенжамин гурван жил амьдраад мөн тэрээр нас барав.

6 Мөнхүү улиран тохиох дор хаан Мозая Их Эзэний замуудаар алхаж, мөн түүний шийдвэрүүдийг мөн түүний тогтоолуудыг мөрдөн, мөн түүний зарлигуудыг тэрээр

15а Кол. 1:16;
Мозая 4:2;
Алма 11:39.
б су Дуудлага ба
Сонгогдогсод;

Ариусгал.
6 1а С ба Г 128:8.
3а Мозая 1:10; 2:30.
б Мозая 5:5–7.
в Алма 4:7.

г су Томилох,
Томилолт.
4а су Мозая,
Бенжамини хүү.
б 1 Ниф. 1:4.

түүнд зарлигласан юунд ч болов бүх зүйлд дагав.

7 Мөн хаан Мозая өөрийн хүмүүсийг тэд газрыг боловсруулахаар болгов. Мөн тэрээр түүнчлэн, өөрөө, газар боловсруулж, тэгснээр тэрээр өөрийн хүмүүст “ачаа болохгүйн тулд, тэрээр бүх зүйлд эцгийнхээ хийж байсны дагуу хийж болохын тулд буюу. Мөн гурван жилийн турш түүний бүх хүмүүсийн дунд зөрчилдөөн байсангүй.

БҮЛЭГ 7

Лимхай хаан нь болох, Лихай-Нифайн нутгийг Аммон олов— Лимхайн хүмүүс леменчүүдэд боолчлогдов— Лимхай өөрсдийн түүхийг өгүүлэв— Бошиглогч (Абинадай) Христ бол Бурхан мөн бүх зүйлийн Эцэг гэдгийг гэрчилдэг байв— Бузрыг тарьсан тэд хар салхийг хурааж авна, мөн Их Эзэнд найдлага тавьсан тэд чөлөөлөгдөх болно. Ойролцоогоор мээ 121 он.

Мөн эдүгээ, улиран тохиох дор хаан Мозая гурван жилийн турш үргэлжилсэн амгалангийн дараа, тэрээр Лихай-Нифайн нутагт, өөрөөр хэлбэл Лихай-Нифайн хотод оршин суухаар “явсан хүмүүсийн талаар мэдэх хүсэлтэй байв; учир нь түүний хүмүүс тэд ⁶Зарахемлагийн нутгийг орхисон цагаас хойш тэднээс юухан ч дуулсангүй; тиймийн тул, тэд байнгын

гуйлтаараа түүнийг ядраасан ажээ.

2 Мөнхүү улиран тохиох дор хаан Мозая хүчит эрсээс арван зургааг нь Лихай-Нифайн нутаг өөд, ах дүүсийнхээ талаар сураглахаар явж болохыг зөвшөөрөв.

3 Мөнхүү улиран тохиох дор тэд маргааш нь өгсөн явж эхэлсэн аж, тэдэнтэй Аммон гэгч нэгэн байв, тэрээр хүчтэй мөн чадалтай эр, мөн Зарахемлагийн удам байв; мөн тэрээр түүнчлэн тэдний удирдагч байлаа.

4 Мөн эдүгээ, тэд Лихай-Нифайн нутаг өөд очихын тулд аглаг буйдад аялах ёстой замаа мэдсэнгүй; тиймийн тул тэд олон өдөр аглаг буйдад бэдрэв, бүр дөчин өдөр тэд бэдэрсэн ажгуу.

5 Мөн тэд дөчин өдөр бэдэрээд “Шиломын нутгийн умардад байх нэгэн толгой дээр ирэв, мөн тэнд тэд майхнуудаа босгов.

6 Мөн Аммон ах дүүсээсээ гурвыг нь авч, тэдний нэрийг Амаликай, Хелем, Хем гэдэг байв, мөн тэд “Нифайн нутагт уруудан одлоо.

7 Мөн болгоогтун, тэд Нифайн нутагт, мөн Шиломын нутагт байсан хүмүүсийн хаантай уулзав; мөн тэд хааны харуулуудаар бүслэгдэн, мөн баривчлагдаж, мөн хүлэгдэж, мөн шоронд хоригдсон ажээ.

8 Мөнхүү улиран тохиох дор тэд шоронд хоёр өдөр байсны

дараа дахин хааны өмнө авчрагдаж, мөн тэдний хүлэг нь тайлагдав; мөн тэд хааны өмнө зогсож, мөн тэднээс түүний асуух асуултанд хариулахаар зөвшөөрөгдсөн байв, эсвээс зарлиглуулсан болой.

9 Мөн тэрээр тэдэнд хэлсэн нь: Болгоогтун, би бол “Лимхай, өөрсдийн эцэг өвгөдийн нутаг асан, энэ нутгийг өвлөхөөр Зарахемлагийн нутгаас гарч ирсэн тэрбээр, хүмүүсийн саналаар хаан болгогдсон Зенифийн хүү асан Ноагийн хүү билээ.

10 Мөн эдүгээ, та нар намайг, өөрийн биеэр, харуулуудтайгаа хэрмийн гадна байхад юуны учир хотын хэрмэнд ойртон ирэх зориг гаргасан билээ гэдгийг мэдэхийг би хүснэ?

11 Мөн эдүгээ, би та нараас асууж болно хэмээх энэ шалтгааны учир би та нарыг хадгалахыг зөвшөөрсөн юм эс бөгөөс би та нарыг үхүүл хэмээн харуулууддаа тушаах ёстой байсан. Та нарт ярих нь зөвшөөрөгдлөө.

12 Мөн эдүгээ, Аммон ярихыг зөвшөөрөгдсөнийг хараад, тэрээр дөхөж очин хааны өмнө бөхийв; мөн буцан өндийгөөд тэрээр хэлэв: Ай хаантан, би амьд байж, мөн ярихаар зөвшөөрөгдсөний учир энэ өдөр Бурханы өмнө ихэд талархана; мөн би зоригтойгоор ярихыг хичээх болно;

13 Учир нь хэрэв та нар намайг мэддэг байсан аваас та

нар намайг ингэж хүлээсээр хүлэхийг зөвшөөрөхгүй байсныг би лавтайяа мэднэ. Учир нь би Аммон, мөн “Зарахемлагийн удам, мөн Зениф тэр нутгаас гарган авчирсан ах дүүсийнхээ талаар сураглахаар Зарахемлагийн нутгаас гарч ирсэн бөлгөө.

14 Мөн эдүгээ, улиран тохиох дор Лимхай, Аммоны үгсийг сонссоны дараа, тэрээр үлэмж баярлан, мөн хэлэв: Эдүгээ, Зарахемлагийн нутагт байсан ах дүү нар минь одоо болтол амьд гэдгийг би лавтайяа мэдлээ. Мөн эдүгээ, би баясах болно; мөн маргааш би өөрийн хүмүүсийг түүнчлэн баясгана.

15 Учир нь болгоогтун, бид леменчүүдийн боолчлолд байж, мөн үүрэхэд хүнд татварыг “татварлуулж буй. Мөн эдүгээ, болгоогтун, ах дүүс маань биднийг боолчлолоос, эсвээс леменчүүдийн гараас гаргаж авах болно, мөн бид тэдний боолууд байх болно; учир нь бид нифайчуудад боол байх нь леменчүүдийн хаанд алба төлөхөөс хавьгүй дээр болой.

16 Мөн эдүгээ, хаан Лимхай өөрийн харуулуудад тэд Аммоныг бас түүний ах дүүсийг нь ч ахин хүлэх ёсгүйг зарлиглав, харин тэд Шиломын умардад байх толгой уруу явж, мөн тэд идэж, ууж, мөн аяны алжаалаа тайлж болохын тулд тэдний ах дүүсийг хотод авчрахыг тушаав; учир

нь тэд олон зүйлийг тэвчсэн байв; тэд өлсгөлөн, цангалтыг мөн зүдрэлийг тэвчсэн буюу.

17 Мөн эдүгээ, улиран тохиох дор маргааш нь хаан Лимхай өөрийн бүх хүмүүсийн дунд зар бичиг илгээв, тэгснээр түүний тэдэнд ярих үгсийг сонсохоор тэд “ариун сүмд өөрсдөө нэгдэн цугларцгааж болохын тулд билээ.

18 Мөнхүү улиран тохиох дор тэднийг цуглармагц тэрээр тэдэнд хандан энэ маягаар ярьж, өгүүлсэн нь: Ай та нар, хүмүүс минь, тэргүүнээ өргөгтүн мөн тайтгар; учир нь болгоогтун, бид дайснуудынхаа эрхшээлд байхаа болих тэр цаг ойртлоо, эсвээс холгүй боллоо, талаар өнгөрсөн бидний олон тэмцэл байсан хэдий ч; хойшид тэмцэл маань үр дүнд хүрэх буйза хэмээн найдна би.

19 Тиймийн тул, тэргүүнээ өргөгцөө, мөн баяс, мөн найдлагаа “Бурханд, Абрахам, мөн Исаак, мөн Иаковын Бурхан байсан тэрхүү Бурханд хандуул; мөн түүнчлэн, Израилын хүүхдүүдийг Египетийн нутгаас ⁶гаргаж авчирсан, мөн тэднийг Улаан Тэнгисийг гатлан хуурай газар дээгүүр алхах болгосон, мөн тэд аглаг буйдад мөхөхгүй байж болохын тулд, тэднийг ^аманнагаар хооллосон тэрхүү Бурхан билээ; мөн тэрээр тэдний

төлөө өөр олон зүйлийг хийсэн юм.

20 Мөн түүнчлэн, эл Бурхан бидний эцэг өвгөдийг Иерусалим нутгаас “гарган авчирсан, мөн өөрийн хүмүүсийг бүр өдий болтол хамгаалж мөн хадгалсан болой; мөн болгоогтун, энэ нь бидний алдсууд мөн жигшүүрт хэргүүдийн учир тэрээр биднийг боолчлолд оруулсан болой.

21 Мөн энэ өдөр та нар бүгд үүний гэрчүүд, энэ хүмүүсийн дээр хаан болгогдсон тэр Зениф, тэрээр эцэг өвгөдийнхөө нутгийг өвлөх “дэндүү их хүсэлтэй байсан учир, тиймийн тул хаан Зенифтэй хэлэлцээр хийсэн хаан Лемений зальт мөн башир аргад мэхлэгдсэн байв, мөн түүний гарт нутгийн нэг хэсэг эзэмшлийг, бүр Лихай-Нифай хотыг, мөн Шиломын хотыг мөн эргэн тойрны нутгийг алдсан болой—

22 Мөн энэ бүхнийг тэрээр хийсэн нь, энэ хүмүүсийг эрхшээлдээ эсвэл боолчлолд “авчрах цорын ганц зорилгын учир болой. Мөн болгоогтун, бид энэ цагт леменчүүдийн хаанд алба гувчуур болгон, өөрсдийн эрдэнэ шишийн тэн хагасыг, мөн өөрсдийн арвайн, мөн бүр өөрсдийн төрөл бүрийн үр тарианы, мөн өөрсдийн бог болон бод малын өссөний нь тэн хагасыг

17a 2 Ниф. 5:16.

19a Ег. 3:6;

1 Ниф. 19:10.

б Ег. 12:40–41;

Алма 36:28.

в Ег. 16:15, 35;

Тоол. 11:7–8;

Иош. 5:12.

20a 1 Ниф. 2:1–4.

21a Мозая 9:1–3.

22a Мозая 10:18.

төлдөг; мөн леменчүүдийн хаан түүгээр ч зогсохгүй бидэнд байгаа бүх эзэмшлийн маань тэн хагасыг эсвээс бидний амийг биднээс шаарддаг.

23 Мөн эдүгээ, энэ нь үүрэхэд хүнд бус уу? Мөн бидний энэ зүдгүүр агуу бус уу? Эдүгээ болгоогтун, бидний гашуудах шалтгаан хичнээн агуу билээ.

24 Тийм ээ, би та нарт хэлнэ, бидний гашуудах шалтгаанууд нь агуу болой; учир нь болгоогтун бидний ах дүүсийн хичнээн нь алагдсан билээ, мөн тэдний цус дэмий асгарсан шүү дээ, мөн бүгд алдсын учир болой.

25 Учир нь хэрэв энэ хүмүүс зөрчилд унаагүй сэн бол энэ агуу хилэнц тэдний дээр ирэхийг Их Эзэн хүлцэхгүй байсан буйза. Гэвч болгоогтун, тэд түүний үгсийг сонссон нь үгүй; харин тэдний дунд зөрчилдөөн бий болж, бүр тэд өөрсдийнхөө дунд цус урсгасан нь тийм их байв.

26 Мөн Их Эзэний “бошиглогчийг; тийм ээ, Бурханаар сонгогдсон хүнийг, тэдний ёс бус мөн жигшүүрт хэргүүдийнх нь талаар тэдэнд хэлсэн, мөн болох олон зүйлийг, тийм ээ, бүр Христийн ирэлтийг бошиглосон түүнийг тэд хөнөөсөн юм.

27 Мөн тэрээр тэдэнд Христ бол “Бурхан, бүх зүйлийн

Эцэг гэдгийг хэлж, мөн тэрээр өөрийн дээр хүний дүрийг авна, мөн энэ нь эхлэлд хүмүүн дууриагдан бүтээгдсэн тэрхүү ⁶дүрслэл болохыг хэлснийг учир буюу; эсвээс өөр үгээр бол, тэрээр хүмүүн нь Бурханы ⁶дүр төрхийн дагуу бүтээгдсэнийг хэлж, мөн Бурхан хүмүүний үрсийн дунд доош ирэх ёстой, мөн өөр дээрээ маханбодь болон цусыг авах ёстойг, мөн газрын гадаргуу дээр урагшлан явах ёстойг хэлсэн бөлгөө —

28 Мөн эдүгээ, тэрээр үүнийг хэлсэн учир, тэд түүнийг үхэлд хүргэжээ; мөн тэд Бурханы хилэнг доош өөрсдийн дээр авчрах өөр олон зүйлийг үйлдсэн билээ. Тиймийн тул, тэд боолчлолд байгаад, мөн тэд зовлонт зүдгүүрүүдээр цохигдсонд хэн гайхширах билээ?

29 Учир нь болгоогтун, Их Эзэн хэлсэн нь: зөрчлийнхээ өдөрт буй өөрийн хүмүүсийг би “халамжлахгүй; харин тэд хөгжин дэвшихгүйн тулд тэдний замд би саад тавих болно; мөн тэдний үйлүүд өөрсдийнх өмнө тээглэх чулуу лугаа адил байх болно.

30 Мөн түүнчлэн тэрээр хэлэх: Хэрэв миний хүмүүс “бузрыг тарих аваас түүнийхээ хаягдлыг салхин хүрдэнд ⁶хурааж авах болно; мөн үүний үр дүн нь хор байх буюу.

26a Мозая 17:12–20.

27a су Бурхан, Бурхан тэргүүтэн.

б Эхл. 1:26–28;

Ифер 3:14–17;

С ба Г 20:17–18.

в Мозая 13:33–34;
15:1–4.

29a 1 Сам. 12:15;

Шаст. дэд 24:20.

30a су Бузар, Бузар явдал.

б Гал. 6:7–8;

С ба Г 6:33.

су Ургац хураалт.

31 Мөн түүнчлэн тэрээр хэлэв: Хэрэв миний хүмүүс бузрыг тарих аваас устгалыг даруй авчрагч “дорнын салхийг хураан авах болно.

32 Мөн эдүгээ, болгоогтун, Их Эзэний амлалт биелсэн, мөн та нар цохигдсон бас зовоогдсон болой.

33 Гэвч хэрэв та нар зүрх сэтгэлийн дүүрэн зорилготойгоор Их Эзэнд “хандвал, мөн найдвараа түүнд өгвөл, мөн оюуныхаа бүх чармайлтаар түүнд үйлчилбэл, хэрэв та нар үүнийг хийвэл, тэрээр таалал мөн хүслийнхээ дагуу, та нарыг боолчлолоос гарган чөлөөлөх болно.

БҮЛЭГ 8

Аммон Лимхайн хүмүүст сургав — Тэрээр жаредчуудын хорин дөрвөн ялтсын тухай сонсож мэдэв — Эртний цэдгүүд үзмэрчдээр орчуулагдаж болно — Үзмэрч байхаас илүү бэлэг гэж үгүй. Ойролцоогоор мээ 121 он.

Мөнхүү улиран тохиох дор хаан Лимхай өөрийн хүмүүст ярьснаа төгсгөл болгосны дараа, учир нь тэрээр тэдэнд олон зүйлийг ярьсан мөн зөвхөн тэдгээрийн цөөнийг нь би энэ номонд бичиглэснийг, тэрээр Зарахемлагийн нутагт байсан ах дүүсийнхээ талаар бүх зүйлийг өөрийн хүмүүст ярьсан болно.

2 Мөн тэрээр Аммоныг олон түмний өмнө босгож, мөн

тэдэнд Зениф уг нутгаас гарсан тэр цагаас бүр тэр өөрөө уг нутгаас гарч ирэх тэр цагийг хүртэл тэдний ах дүүст тохиолдсон бүгдийг тоочихоор болгов.

3 Мөн тэрээр түүнчлэн хаан Бенжамины тэдэнд заасан эцсийн үгсийг тэдэнд давтан хэлж, мөн хаан Лимхайн хүмүүст тэд түүний ярьсан бүх үгийг ойлгож болохын тулд тэдгээрийг тайлбарлав.

4 Мөнхүү улиран тохиох дор тэрээр энэ бүгдийг хийсний дараа, хаан Лимхай олон түмнийг тарааж, мөн тэд хүн бүрийг гэртээ эргэж очих болгов.

5 Мөнхүү улиран тохиох дор тэрээр, тэд Зарахемлагийн нутгийг орхисон цагаас түүний хүмүүсийн “цэдгийг тээсэн ялтсуудыг, тэрээр тэдгээрийг уншиж болохын тулд Аммоны өмнө авчрагдахаар болгов.

6 Эдүгээ, Аммон уг ялтсыг уншмагц, тэрээр хэлийг хөрвүүлж чадах эсэхийг мэдэхээр хаан түүнээс асуув, мөн Аммон чадахгүйгээ түүнд хэлэв.

7 Мөн хаан түүнд хэлэв: өөрийн хүмүүсийн зовлон зүдгүүрийн төлөө би гашуудсан учир, тэд Зарахемлагийн нутгийг олж болохын тулд, биднийг боолчлолоос чөлөөлөхийг бид гуйж болохын тулд, ах дүүсээсээ би өөрийн хүмүүсээс дөчин гурвыг аглаг буйдад замд гаргасан билээ.

8 Мөн тэд аглаг буйдад олон өдрийн турш төөрчээ, гэвч тэд шаргуу байсан аж, гэвч Зарахемлагийн нутгийг олсонгүй, харин их усны дундах нутагт аялсны дараа, хүний мөн амьтны ясаар хучигдсан, мөн түүнчлэн янз бүрийн барилгуудын балгасуудаар дүүрсэн нэгэн нутагт очсоны дараа, Израилын олны адил тоолшгүй байсан хүмүүсээр эзэгнэгдэж асан нутгийг олж мэдсэнийхээ дараа харин энэ нутагтаа эргэж иржээ.

9 Мөн тэд хэлсэн зүйлүүдийнхээ үнэний гэрчлэл болгон сийлбэрээр дүүрэн, мөн цэвэр алт болох “хорин дөрвөн ялтсыг авчирсан болой.

10 Мөн болгоогтун, түүнчлэн, тэд том, мөн “гууль мөн ээсэн, мөн бүх талаараа төгс сайн ⁶цээжний хуягуудыг авчирсан бөлгөө.

11 Мөн түүнчлэн, тэд илднүүдийг авчрав, тэдгээрийн бариулууд нь өгөр даасан, мөн ирт хэсгүүд нь зэвэнд идэгдсэн байв; мөн ялтсууд дээрх сийлбэрүүд эсвэл уг хэлийг хөрвүүлж чадах хэн ч энэ нутагт байсангүй. Тиймийн тул би танд хэлсэн билээ: Та орчуулж чадах сан болов уу?

12 Мөн би танд дахин хэлье: Та орчуулж чадах хэн нэгийг мэдэх сэн болов уу? Учир нь би эдгээр цэдгүүд бидний хэлэнд орчуулагда-

хыг хүснэ; учир нь магадгүй, эдгээр ялтсууд ирсэн тэнд байсан эдгээр нь устгагдсан хүмүүсийн үлдэгдлийн тухай мэдлэгийг бидэнд өгөх болно; эсвээс, магадгүй, тэдгээр нь чухам устгагдсан тэр хүмүүсийн тухай мэдлэгийг бидэнд өгөх болно; мөн би тэдний устгалын шалтгааныг мэдэх хүсэлтэй байна.

13 Эдүгээ Аммон түүнд хэлэв: Ай хаантан, уг цэдгүүдийг “орчуулж чадах хүний тухайд би танд лавтайяа хэлж чадна; учир нь эрт цагийн бүх цэдгүүдийг үзэж, мөн орчуулж чадах ямар нэгэн зүйл түүнд буй; мөн энэ нь Бурханы бэлэг юм. Мөн уг зүйлүүд ⁶хөрвүүлэгч гэж нэрлэгддэг, мөн зарлигдуулахаас бусдаар бол түүгээр нэг ч хүн харж чадахгүй, харах учиргүй зүйлийг тэрээр хайж мөн тэрээр мөхөх болуузай. Мөн түүгээр харахыг зарлигдуулсан нь, мөнхүү тэр нь “үзмэрч хэмээн нэрлэгддэг болой.

14 Мөн болгоогтун, Зарахемла нутаг дахь тэр хүмүүсийн хаан бол эдгээр зүйлийг хийхээр зарлигдуулсан, мөн Бурханаас энэ өндөр бэлгийг хүртсэн хүн юм.

15 Мөн үзмэрч нь бошиглогчоос агуу гэж хаан хэлэв.

16 Мөн Аммон хэлэхдээ үзмэрч мөн илчлэгч мөн түүнчлэн бошиглогч; мөн хэний ч агуулж үл чадах Бурханы тэрхүү хүчийг агуулснаас

9а Ифер 1:1–2.
10а Ифер 10:23.
б Ифер 15:15.

13а Мозая 28:10–17.
б су Урим ба
Туммим.

в су Үзмэрч.

бусдаар бол, хэн ч үүнээс илүү агуу бэлгийг хүртэж чадахгүй; гэсэн хэдий ч хүмүүнд агуу их хүч Бурханаас өгөгдөж болох бөлгөө.

17 Харин үзмэрч өнгөрсөн зүйлийг, мөн түүнчлэн ирэх зүйлийг мэдэж чадна, мөн тэдгээр бүх зүйл илчлэгдэх болно, эсвээс, чухамдаа, нууц зүйлүүд үзүүлэгдэх болно, мөн далдлагдсан зүйлүүд гэрэлд гарч ирэх болно, мөн мэдэгдээгүй зүйлүүд тэднээр мэдэгдэх болно, мөн түүнчлэн өөр нөхцөлд мэдэгдэж болох зүйлүүд тэднээр мэдэгдэх буюу.

18 Тийн хүмүүн итгэлээрээ дамжуулан, агуу гайхамшигуудыг хийж болох нэгэн аргаар Бурхан хангажээ; тиймийн тул тэрээр бусдадаа агуу ашиг тус хүргэх бөлгөө.

19 Мөн эдүгээ, Аммон эдгээр үгсийг ярихаа төгсгөл болгоход хаан үлэмж баясан, мөн Бурханд талархал илэрхийлж, хэлсэн нь: Эргэлзээгүйгээр нэгэн “агуу нууц эдгээр ялтсуудад тээгдсэн буй, мөн эдгээр хөрвүүлэгчид эргэлзээгүйгээр бүх тийм нууцуудыг хүмүүний үрсэд мэдүүлэх зорилгын тулд бэлтгэгдсэн буйза.

20 Ай Их Эзэний ажлууд хичнээн гайхамшигтай билээ, мөн өөрийн хүмүүсийг тэрээр хичнээн удаан тэсвэрлэдэг билээ; тийм ээ, хүмүүний үрсийн ойлголт ямар харалган мөн нэвтэршгүй

билээ; учир нь тэд мэргэн ухааныг хайх нь үгүй, мөн тэрнийг өөрсдийн дээр захируулах хүсэл ч үгүй болой!

21 Тийм ээ, тэд хоньчноос зугтан мөн бутарч, мөн зайлан холдож, мөн ойн зэрлэг араатнаар цөлмүүлэх зэрлэг сүрэг лугаа адил болой.

Зенифийн цэдэг — тэд Зарахемлагийн нутгийг орхисон цагаас хойш тэд леменчүүдийн гараас чөлөөлөгдсөн цагийг хүртэлх түүний хүмүүсийн шастир оршвой.

9-өөс 22 дугаар бүлэгт агуулагдав.

БҮЛЭГ 9

Зениф Лихай-Нифайн нутгийг эзэмшихээр Зарахемлагаас бүлэг хүмүүсийг удирдав — Лемен үндэстний хаан уг нутгийг өвлөхийг тэдэнд зөвшөөрөв — Леменчүүд болон Зенифийн хүмүүсийн хооронд дайн болов. Ойролцоогоор мээ 200–187 он.

Би, Зениф, нифайчуудын бүх хэлийг заалгасан тул, мөн “Нифайн нутгийн, өөрөөр хэлбэл өөрийн эцэг өвгөдийн анхны өвлүүлсэн нутгийн мэдлэгтэй байсан учир, мөн леменчүүдийн дунд манай их цэрэг тэдний дээр ирж мөн тэднийг устгаж болохын тулд би тэдний хүчийг тагнаж болно хэмээн туршуулаар илгээгдсэн учир — гэвч би тэдний дунд сайн нь байгааг

хараад тэд устгагдахгүй байж болно хэмээх хүсэлтэй байсан болой би.

2 Тиймийн тул, бидний захирагч тэдэнтэй хэлэлцээр хийгээсэй хэмээсэн учир аглаг буйдад би ах дүүстэйгээ маргав; гэвч тэрээр догшин мөн цусанд дуртай хүн байсан учир намайг алагдвал зохино хэмээн зарлигдав; харин их цус урсгасны дүнд би амь гарсан бөлгөө; учир нь эцэг хүн эцэг хүний эсрэг, мөн ах нь дүүгийнхээ эсрэг, аглаг буйд дахь манай их цэргийн ихэнх нь устгагдтал тулалдав; мөн бид амьд үлдсэн тэд Зарахемлагийн нутаг тийш өөрсдийн эхнэр мөн хүүхдүүдэд болсон явдлыг хэлэхээр эргэж ирсэн бөлгөө.

3 Гэсэн хэдий ч, би эцэг өвгөдийнхөө нутгийг өвлөх дэндүү их хүсэлтэй байсан учир, уг нутгийг эзэмшихээр явах хүсэлтэй байсан олныг цуглуулж, мөн уг нутагт очихоор дахин аглаг буйд дахь аянаа эхэлсэн буюу; гэвч бид өлсгөлөн мөн зовлонт зүдгүүрүүдэд цохигдсон болой; учир нь бид Их Эзэн Бурханаа санахдаа хойрго байв.

4 Гэсэн хэдий ч, олон өдөр аглаг буйдад бэдэрсний эцэст бид эцэг өвгөдийн минь нутгийн ойролцоо байсан, ах дүүсийнхээ алагдсан тэр газар майхнуудаа босгов.

5 Мөнхүү улиран тохиох дор би хааны санаа бодлыг мэдэж болохын тулд, мөн өөрийн

хүмүүстэй очиж мөн нутгийг амгалан эзэмшиж болох эсэхийг мэдэж болохын тулд, би дөрвөн хүнийхээ хамт дахин хотод орж хаан дээр очив.

6 Мөн би хаан дээр очиж, мөн тэрээр надтай бибээр Лихай-Нифайн нутгийг мөн Шиломын нутгийг эзэмшиж болохоор гэрээлсэн болой.

7 Мөн түүнчлэн тэрээр өөрийн хүмүүсийг уг нутгаас гарахыг зарлиглаж, мөн би болон миний хүмүүс бид үүнийг эзэмшиж болохын тулд уг нутагт очсон бөлгөө.

8 Мөн бид барилгууд барьж, мөн хотын хэрмийг, тийм ээ, бүр Лихай-Нифай хотын мөн Шилом хотын хэрмийг засч эхлэв.

9 Мөн бид газар боловсруулж, тийм ээ, бүр бүх төрлийн үрээр, эрдэнэ шишийн үрээр, мөн буудай, мөн арвай, мөн нис, мөн шимийн, мөн янз бүрийн жимсний үрээр буюу; мөн бид өнөржин мөн уг нутагт дэгжиж эхэлсэн бөлгөө.

10 Эдүгээ бид үүнийг эзэмшиж болохын тулд уг нутгийг тэрээр өгсөн нь миний хүмүүсийг боолчлолд “авчрах хаан Лемений заль бас башир арга байжээ.

11 Тиймийн тул улиран тохиох дор, бид уг нутагт арванхоёр жил оршсоны дараа, миний хүмүүс уг нутагт хүчирхэгжиж мөн тэд тэднийг хүчээр давамгайлж мөн тэднийг боолчлолд оруулж

чадахгүй болуузай хэмээн аях учир хаан Лемен эмээж эхлэв.

12 Эдүгээ тэд залхуу мөн “хиймэл шүтээн шүтэгч хүмүүс байв; тиймийн тул тэд бидний гарын хөдөлмөрөөр өөрсдийгөө цатгаж болохын тулд, тийм ээ, тэд бэлчээр дэх сүргийн маань дээр өөрсдөө зооглож болохын тулд буюу тэд биднийг боолчлолд оруулах хүсэлтэй байлаа.

13 Тиймийн тул улиран тохиох дор тэднийг миний хүмүүстэй маргаж тэмцэлдүүлэхийн тулд хаан Лемен хүмүүсээ өдөөн хатгаж эхлэв; тиймийн тул уг нутагт дайнууд мөн зөрчилдөөн байж эхлэв.

14 Учир нь, Нифайн нутагт, Шиломын нутгийн өмнөдөд миний засаглалын арвангурав дахь жилд, миний хүмүүс сүргээ усалж мөн тэжээж, мөн газраа боловсруулж байх үед олон тооны леменчүүд тэдэн дээр ирж мөн тэднийг хөнөөж, мөн тэдний сүргийг, мөн тэдний талбай дахь эрдэнэ шишийг олзлон авч эхэллээ.

15 Тийм ээ, мөнхүү улиран тохиох дор тэд зугтаж, бүр Нифайн хотод ортлоо, гүйцэгдээгүй бүгд нь, мөн надаас өмгөөлөл хүсэн дуудав.

16 Мөнхүү улиран тохиох дор би тэднийг нум, мөн сум, илд мөн сэлэм, мөн бороохой, мөн дүүгүүрүүдээр, мөн бид бүтээж чадах л бүх төрлийн зэвсгүүдээр зэвсэглэн, мөн би

болон миний хүмүүс леменчүүдийн эсрэг тулалдахаар давшсан билээ.

17 Тийм ээ, Их Эзэний хүчинд бид леменчүүдийн эсрэг тулалдахаар давшин явав; учир нь би болон миний хүмүүс, тэрээр биднийг дайснуудын маань гараас чөлөөлөөсэй хэмээн Их Эзэнд хүчтэйгээр гуйн залбирсан болой, учир нь бид эцэг өвгөдийнхөө чөлөөлөлтийн тухай дурсамжинд сэрээгдсэн болой.

18 Мөн Бурхан бидний гуйлтыг “анлааран сонсож, мөн бидний залбирлуудад хариулсан билээ; мөн бид түүний хүчинд урагш давшив; тийм ээ, бид леменчүүдийн эсрэг урагш давшиж, мөн нэг өдөр мөн нэг шөнийн дотор бид гурван мянга дөчин гурвыг хөнөөв; бид тэднийг бүр нутгаасаа зайлуулан гаргатал хөнөөсөн бөлгөө.

19 Мөн би, өөрөө, өөрийн гараар, тэдний үхэгсдийг оршуулахад туслав. Мөн болгоогтун, бидний агуу харамсал мөн гашуудал болж, ах дүүсийн маань хоёр зуун далан ес нь алагдсан байв.

БҮЛЭГ 10

Хаан Лемен насан эцэслэв—Түүний хүмүүс зэрлэг мөн догшин ширүүн мөн хуурамч заншлуудад итгэдэг болой—Зениф болон түүний хүмүүс тэдний эсрэг давамгайлав. Ойролцоогоор мээ 187–160 он.

Мөнхүү улиран тохиох дор бид хаант улсыг дахин тохиуулж эхлэн мөн бид уг нутгийг дахин энх амгалан байдалд эзэмшиж эхлэв. Мөн леменчүүд миний хүмүүсийн эсрэг дайтахаар ирэх тэр цагт өөрийн хүмүүст зориулах зэр эвсгүүд надад байж болохын тулд би дайны төрөл бүрийн эвсгүүд хийгдэхээр болгов.

2 Мөн леменчүүд санамсаргүй байхад маань бидний дээр дахин ирж мөн биднийг устгаж чадахгүйн тулд би нутгийн эргэн тойронд харуулууд гаргав; мөн тийн би хүмүүсээ мөн мал сүргээ харгалзаж, мөн тэднийг дайснуудынхаа гарт орохоос хамгаалж байв.

3 Мөнхүү улиран тохиох дор эцэг өвгөдийн нутгийг бид олон жил, тийм ээ, хорин хоёр жилийн турш өвлөн суув.

4 Мөн би эрчүүдийг газар боловсруулан, мөн бүх төрлийн “тариа мөн янз бүрийн жимсний бүх төрлийг ургуулах болгосон билээ.

5 Мөн бид нүцгэнээ хувцаслаж болохын тулд эмэгтэйчүүдийг утас ээрэх, нөр хөдөлмөрлөх хийгээд ажиллах, мөн бүх төрлийн “нарийн нэхээст эд хийх, тийм ээ, мөн төрөл бүрийн даавуу хийхээр болгосон билээ би; мөн ийн бид уг нутагт дэгжив—ийн бид уг нутагт хорин хоёр жилийн турш үргэлжийн энх амгалан байв.

6 Мөнхүү улиран тохиох дор хаан “Лемен насан эцэслэв, мөн түүний оронд хүү нь засаглаж эхлэв. Мөн тэрээр өөрийн хүмүүсийг миний хүмүүсийн эсрэг эсэргүүцэлд өдөөн хатгав; тиймийн тул тэд дайнд бэлтгэж, мөн миний хүмүүсийн эсрэг тулалдахаар ирж эхлэв.

7 Гэвч би тэдний бэлтгэлийг олж мэдэж болохын тулд, тэд миний хүмүүс дээр ирж мөн тэднийг устгаж болзошгүйн учир, би тэдний эсрэг хамгаалж болно хэмээн туршуулуудаа “Шимлон нутгийн эргэн тойронд илгээсэн болой.

8 Мөнхүү улиран тохиох дор тэд Шилом нутгийн умардад, олон тооны хүмүүстэйгээ, эрчүүд нь “нумаар, мөн сумаар, мөн сэлмээр, мөн илдээр, мөн чулуу, мөн дүүгүүрүүдээр “зэвсэглэн ирэв; мөн тэд үсээ хусуулсан учир толгой нүцгэн байв; мөн тэд хэвлийн тус газартаа ширэн халхавч бүсэлжээ.

9 Мөнхүү улиран тохиох дор би хүмүүсийнхээ эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийг нь аглаж буйдад нуугдахаар болгов; мөн түүнчлэн зэвсэг хэрэглэж чадах өөрийн бүх настай эрчүүдийг, мөн түүнчлэн зэвсэг хэрэглэх боломжтой бүх залуу эрчүүдээ, леменчүүдийн эсрэг тулалдахаар нэгдэн цугларахаар болгов би; мөн би тэднийг насных нь дагуу

хүн бүрийг эрэмбэлэн эгнээнд нь байрлуулсан бөлгөө.

10 Мөнхүү улиран тохиох дор бид леменчүүдийн эсрэг тулалдахаар явав; мөн би, бүр би хүртэл, өтөл насандаа, леменчүүдийн эсрэг тулалдахаар явав. Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний “хүчинд бид тулалдахаар явсан болой.

11 Эдүгээ, леменчүүд Их Эзэний талаар, бас Их Эзэний хүчний талаар юу ч эс мэддэг, тиймийн тул тэд өөрсдийн хүчинд тулгуурлаж байв. Гэсэн ч тэд хүмүүний хүч чадлын хувьд хүчирхэг хүмүүс байлаа.

12 Тэд “зэрлэг, мөн догшин ширүүн, мөн цусанд шунасан хүмүүс, эцэг өвгөдийнхөө ^бзаншилд итгэдэг байв, тэр нь — тэд эцэг өвгөд нь алдсуудын учир Иерусалим нутгаас хөөгдөн гарсан гэдэгт, мөн тэд аглаг буйдад өөрсдийн ах дүүсээр шударга бусаар сүйтгэгдсэн, мөн тэд түүнчлэн далай гатлах үедээ шударга бусаар сүйтгэгдсэн гэдэгт итгэдэг байсан бөлгөө;

13 Мөн түүнчлэн, тэд далайг гаталсны дараа “анхны өвийн нутагтаа байх зуур тэд сүйтгэгдсэн гэдэгт, мөн энэ бүгд Нифай Их Эзэний зарлигуудыг дагахдаа илүү итгэлтэй байсны учир — тиймийн тул тэрээр Их Эзэнээр ^бөндөр их ээл хишиг хүртээгдсэн аж, учир нь Их Эзэн түүний зал-

бирлуудыг анхааран сонсож мөн тэдгээрт хариулсан байв, мөн тэрээр аглаг буйд дахь аяныхаа удирдлагыг авчээ.

14 Мөн түүний ах нар Их Эзэний үйл хэргүүдийг үл “ойлгохын учир түүнд хилэгнэж байсан ажээ; тэд түүнчлэн Их Эзэний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулсаны учир их усан дээр түүнд тэд ^бхилэгнэсэн бөлгөө.

15 Мөн түүнчлэн, тэд амлагдсан нутагт хүрч ирэхдээ, тэд хүмүүсийг “удирдах эрхийг тэдний гараас тэрээр булаан авсан хэмээсний учир тэд түүнд хилэгнэсэн аж; мөн тэд түүнийг егүүтгэхийг эрэлхийлсэн болой.

16 Мөн түүнчлэн, тэрээр Их Эзэн түүнд зарлигласны дагуу аглаг буйдад одож мөн гуулин ялтсууд дээр сийлбэрлэгдсэн “цэдгүүдийг авсан учир тэд түүнд хилэгнэсэн аж, учир нь тэрээр тэднийг ^бдээрэмдсэн хэмээн тэд хэлжээ.

17 Мөн тийн тэд хүүхдүүддээ тэд тэднийг үзэн ядах, мөн тэд тэднийг алан хядаж, мөн тэд тэднийг дээрэмдэн мөн тэднийг тонох, мөн тэд бүгд тэднийг устгахын тулд чадах бүхнээ хийвэл зохино хэмээн сургасаар ирсэн билээ; тиймийн тул тэд Нифайн үрсийн талаар мөнхийн үзэн ядалтыг агуулдаг.

18 Чухам энэхүү шалтгааны учир хаан Лемен өөрийн заль

10а су Итгэл.

12а Алма 17:14.

б 2 Ниф. 5:1–3.

13а 1 Ниф. 18:23.

б 1 Ниф. 17:35.

14а 1 Ниф. 15:7–11.

б 1 Ниф. 18:10–11.

15а 2 Ниф. 5:3.

16а 2 Ниф. 5:12.

б Алма 20:10, 13.

мэх, мөн хуурамч башир арга, мөн сайхан амлалтуудаараа намайг залилсан юм, иймээс тэд тэднийг устгаж болохын улмаас билээ, би өөрийн энэ хүмүүсийг энэ нутагт авчирсан; тийм ээ, мөн бид энэ олон жилийг уг нутагт зовж өнгөрөөв.

19 Мөн эдүгээ би, Зениф, леменчүүдийн талаар эдгээр бүх зүйлийг өөрийн хүмүүст хэлсний дараа, би тэднийг өөрсдийн хүчээр, Их Эзэнд найдлагаа тавин, тулалдахаар явахыг тэдэнд уриалав; тиймийн тул, бид тэдэнтэй нүүр тулан тэмцэлдэв.

20 Мөнхүү улиран тохиох дор бид тэднийг нутгаасаа дахин гаргав; мөн бид тэднийг хөнөөсөн нь асар их аллага болж, бүр бид тэднийг тоолшгүй тийм олон байсан бөлгөө.

21 Мөнхүү улиран тохиох дор бид нутагтаа эргэж ирэв, мөн миний хүмүүс дахин мал сүргээ адуулж, мөн газраа боловсруулж эхлэв.

22 Мөн эдүгээ би, өтөлсний учир, хөвгүүдийнхээ нэгэнд хаант улсыг шилжүүлэн өгөв; тиймийн тул, би өөрийг үл хэлнэ, мөн Их Эзэн миний хүмүүсийг адислах болтугай. Амен.

БҮЛЭГ 11

Хаан Ноа ёсон бусаар захирав—

Тэрээр эхнэрүүд мөн татвар эмстэйгээ үймээн шуугиантай амьдарч зугаацах бөлгөө— Хүмүүс боолчлолд аваачигдах болно хэмээн Абинадай бошиглов— Түүний амийг хаан Ноа эрэлхийлэв. Ойролцоогоор мээ 160–150 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Зениф хаант улсыг хөвгүүдийнхээ нэг болох Ноад шилжүүлэв; тиймийн тул Ноа түүний оронд засаглаж эхлэв; мөн тэрээр эцгийнхээ замуудаар алхсан нь үгүй.

2 Учир нь болгоогтуун, тэрээр Бурханы зарлигуудыг дагасангүй, харин тэр зүрх сэтгэлийнхээ хүслийн дагуу алхсан болой. Мөн тэрээр олон эхнэр мөн “татвар эмстэй байв. Мөн тэр өөрийн хүмүүсийг нүгэл үйлдэж мөн Их Эзэний мэлмийд жигшүүрт болох тэрнийг үйлдэх болгов. Тийм ээ, мөн тэд “сатар самууныг мөн бүх төрлийн ёс бусыг үйлдсэн болой.

3 Мөн тэрээр тэдний эзэмшсэн бүгдийн тавны нэгийг, алтных нь мөн мөнгөнийх нь тавны нэгийг, мөн “зифийнх нь, мөн тэдний зэс, гууль мөн тэдний төмрийнх нь тавны нэгийг, мөн төл малынх нь тавны нэгийг; мөн түүнчлэн тэдний бүх үр тарианы тавны нэгийг татвар болгон тогтоов.

4 Мөн энэ бүгдийг тэр өөрийгөө, мөн эхнэрүүдээ мөн татвар эмсээ, мөн түүнчлэн санваартнуудаа, мөн тэдний

11 2a Иаков 3:5.
б Хаад. дээд 14:15–16;
Мозая 29:31.

в 2 Ниф. 28:15.
3a Евр. Хоорондоо
холбоотой үгс:

“гэрэлтсэн” тэмдэг
нэр, үйл үг.

эхнэрүүд мөн тэдний татвар эмсийг тэтгэхээр авчээ; тийн тэрээр хаант улсын хэргийг өөрчлөв.

5 Учир нь тэрээр түүний эцгээр адислан томилогдсон бүх санваартнуудыг буулгаж, мөн тэдний оронд сэтгэл зүрхнийхээ бардамналд хөөрсөн тийм шинүүдийг адислан томилсон буюу.

6 Тийм ээ, мөн тэд хаан Ноа өөрийн хүмүүст тохоосон татваруудаар өөрсдийн залхуу, мөн өөрсдийн хиймлийг шүтэх явдалд, мөн өөрсдийн садар самуун явдлуудад тийн тэтгэгдсэн буюу; тийн нь алдсыг тэтгэхийн тулд уг хүмүүс үлэмж хөдөлмөрлөсөн ажээ.

7 Тийм ээ, мөн тэд хаан болон санваартнуудын хоосон мөн зусар үгсээр мэхлэгдсэн учир, түүнчлэн тэд хиймлийг шүтэгчид болов; учир нь тэдэнд зусардсан зүйлийг тэд ярьдаг байв.

8 Мөнхүү улиран тохиох дор хаан Ноа олон тансаг мөн цэлгэр барилгуудыг барьжээ; мөн тэрээр тэдгээрийг төрөл бүрийн үнэт зүйлүүдээр, модоор, мөн алт, мөн мөнгө, мөн төмөр, мөн гууль, мөн зиф, мөн зэсээр хийсэн уран эдлэлээр чимэглүүлсэн ажээ;

9 Мөн түүнчлэн тэрээр цэлгэр ордон, мөн түүний голд нь хаан сэнтийг өөртөө барьж тэдгээр нь бүгд сайн модоор хийгдэж мөн алт болон мөнгө мөн үнэт зүйлүүдээр чимэглэгдсэн байв.

10 Мөн түүнчлэн тэрээр ажилчдаараа сайн чанарын мод, мөн зэс, мөн гуулиар ариун сүмийн ханан дотор бүх төрлийн уран эдлэлийг хийх болгосон бөлгөө.

11 Мөн дээд санваартнуудын суухад зориулагдсан, бусад бүх суудлуудаас дээр байсан тэр суудлуудыг, тэр шижир алтаар чимэглэсэн аж; мөн тэр тэдний өмнө хашлага бариулав, хуурамч болоод хоосон үгсийг түүний хүмүүст ярьснаар тэд биеэ болон гарраа амрааж болох ажгуу.

12 Мөнхүү улиран тохиох дор тэрээр ариун сүмийн дэргэд “цамхаг барив; тийм ээ, маш өндөр цамхаг, бүр тэрээр түүний дээр зогсоод Шилом нутгийг, мөн түүнчлэн леменчүүдээр эзэмшигдсэн, Шимлон нутгийг бүхэлд нь харж чадахаар өндөр буюу; мөн тэрээр бүр эргэн тойрныхоо бүх нутгийг харж чаддаг байв.

13 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Шиломын нутагт олон барилга бариулав; мөн тэд нутгаас зугтан гарсан тэр цагт Нифайн хүүхдүүдэд хоргодох газар болсон Шилом нутгийн умардад толгой дээр агуу цамхаг бариулсан аж; мөн өөрийн хүмүүсээс татварлаж олсон тэрхүү баялгаараа тэрээр тийн хийсэн болой.

14 Мөнхүү улиран тохиох дор тэрээр зүрх сэтгэлээ баялгуудынхаа дээр тавьж, мөн тэр

цагаа эхнэрүүд мөн татвар эмсийнхээ хамт шуугиант амьдралд өнгөрөөдөг байлаа; мөн түүний санваартнууд түүнчлэн цагаа садар эмстэй өнгөрөөдөг байв.

15 Мөнхүү улиран тохиох дор уг нутгийн эргэн тойронд тэрээр усан үзэм тариалжээ; мөн тэрээр усан үзэм дарагч барьж, мөн элбэг их дарс хийв; мөн тиймийн тул тэрээр мөн түүнчлэн хүмүүс нь ч “дарсанд халагсад болов.

16 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд түүний хүмүүс дээр, цөөн тоогоороо байхад нь ирж эхлэв, мөн тэднийг өөрсдийнх нь талбай дээр, мөн тэднийг сүргээ хариулж явахад нь хөнөөж эхлэв.

17 Мөн хаан Ноа тэднээс хамгаалуулахаар нутгийнхаа эргэн тойронд харуулууд илгээв; гэвч тэр хангалттай тоогоор илгээсэнгүй, мөн леменчүүд тэдний дээр ирж мөн тэднийг хөнөөгөөд, мөн тэдний мал сүргээс олныг нь уг нутгаас тууж гаргав; тийн леменчүүд тэднийг устгаж мөн тэдний дээрх үзэн ядалтаа бодитой болгож эхлэв.

18 Мөнхүү улиран тохиох дор хаан Ноа их цэргээ тэдний эсрэг илгээж, мөн тэд гэдрэг туугдсан аж, өөрөөр хэлбэл тэд тэднийг хэсэг зуур гэдрэг ухруулав; тиймийн

тул, тэд олзондоо баясаад эргэж ирцгээв.

19 Мөн эдүгээ, энэ их ялалтын учир тэд зүрх сэтгэлийн бардамналд хөөрцгөөсөн байв; тэд хүчиндээ эрдэн “сагсуурцгааж, тэдний тавь нь мянга мянган леменчүүдийн эсрэг зогсож чадна хэмээн өгүүлцгээв; мөн тэд тийн сагсуурцгааж, мөн цусанд, мөн ах дүүсийнхээ цусыг урсгасандаа баясацгаав, мөн энэ нь тэдний хаан мөн санваартнуудын ёс бусын учир буюу.

20 Мөнхүү улиран тохиох дор “Абинадай гэж нэрлэгдэх нэгэн эр тэдний дунд байв; мөн тэрээр тэдний дундуур урагшлан явж, мөн бошиглож эхлэн, хэлсэн нь: Болгоогтун, Их Эзэн тийн хэлнэм, мөн ийн тэрээр надад зарлиглан, хэлрүүн, Урагш яв, мөн энэ хүмүүст хэл, ийн Их Эзэн хэлнэм—Ай энэ хүмүүст халаг, учир нь би тэдний жигшүүрт явдлууд, мөн тэдний ёс бус, мөн тэдний садар самуун явдлыг харсаар байна; мөн тэд наманчлахгүй аваас би хилэнгээрээ тэдэн дээр айлчлах болно.

21 Мөн тэд наманчилж мөн Их Эзэн Бурхандаа хандахгүй аваас, болгоогтун, би тэднийг дайсных нь гарт оруулах болно; тийм ээ, мөн тэд “боолчлолд оруулагдах болно; мөн тэд дайснуудынхаа гараар зовоогдох болно.

22 Мөнхүү улиран тохиох дор би бол Их Эзэн тэдний Бурхан, мөн би өөрийн хүмүүсийн алдсуудад айлчлах “хартай Бурхан гэдгийг тэд мэдэх болно хэмээв.

23 Мөнхүү улиран тохиох дор энэ хүмүүс наманчилж мөн Их Эзэн Бурхандаа хандахгүй аваас, тэд боолчлолд оруулагдах болно; мөн энэ нь Их Эзэн Бүхнийг Чадагч Бурхан байхаас бусдаар бол хэн ч тэднийг чөлөөлөхгүй.

24 Тийм ээ, мөнхүү улиран тохиох дор тэд надад залбиран гуйх үед тэдний гуйлгуудыг сонсохдоо би “удаан байх болно; тийм ээ, мөн тэд дайснудаараа нам цохигдохыг би тэдэнд зөвшөөрөх болно.

25 Мөн тэд үнс түрхэн мөн таар нөмөрч наманчлан, мөн Их Эзэн Бурхандаа хүчтэйгээр залбиран гуйхгүй аваас, би тэдний залбирлуудыг “сонсохгүй, бас би тэднийг зовлонгоос нь ч чөлөөлөхгүй байх болно; мөн Их Эзэн тийн хэлнэм, мөн тэрээр надад тийн зарлигласан болой.

26 Эдүгээ улиран тохиох дор Абинадай эдгээр үгсийг тэдэнд ярихад тэд түүнд хилэгнэж, мөн түүний амийг авахаар эрэлхийлэв; гэвч Их Эзэн тэдний гараас түүнийг чөлөөлөв.

27 Эдүгээ хаан Ноа Абинадайн хүмүүст ярьсан тэр үгсийг дуулаад, тэрээр түүнчлэн

хилэгнэв; мөн тэрээр хэлэв: Би болон миний хүмүүс түүгээр шүүгдэх, Абинадай гэж хэн бэ, эсвээс миний хүмүүсийн дээр тийм агуу зовлон авчрах Их Эзэн гэж “хэн бэ?

28 Би түүнийг алж болохын тулд Абинадайд энд авчрахыг би та нарт тушааж байна, учир нь тэр эдгээр зүйлийг минь хүмүүсийг өөр хооронд нь уурлуулахаар өдөөн хатгаж, мөн миний хүмүүсийн дунд зөрчилдөөн үүсгэж болно хэмээн хэлжээ; тиймийн тул би түүнийг хөнөөх болно.

29 Эдүгээ хүмүүсийн нүд “харалган болсон байв; тиймийн тул тэд Абинадайн үгсийн эсрэг зүрх сэтгэлээ хатууруулж, мөн тэд тэр цагаас хойшид түүнийг барихаар эрэлхийлсэн буюу. Мөн Их Эзэний үгсийн эсрэг хаан Ноа зүрх сэтгэлээ хатууруулж, мөн тэрээр хилэнцэт үйлүүдээ наманчилсан нь үгүй.

БҮЛЭГ 12

Абинадай хүмүүсийн устгал мөн хаан Ноагийн үхлийг бошиглосон учир шоронд хоригдов — Хуурамч санваартнууд судраас иш татан мөн Мосегийн хуулийг дагаж буй дүр үзүүлэв — Абинадай тэдэнд Арван Зарлигийг зааж эхлэв. Ойролцоогоор мээ 148 он.

Мөнхүү улиран тохиох дор

22a Ег. 20:5;
Дэд хууль 6:15;
Мозая 13:13.
24a Мика 3:4;

Мозая 21:15.
25a Иса. 1:15; 59:2.
27a Ег. 5:2; Мозая 12:13.
29a Мосе 4:4.

б Алма 33:20;
Ифер 11:13.

хоёр жилийн дараа Абинадай, тэд түүнийг эс мэдэхийн тул тэдний дунд зүсээ хувирган ирж, мөн тэдний дунд бошиглож эхлэн, өгүүлсэн нь: Тийн Их Эзэн надад зарлигласан буюу, хэлрүүн — Абинадай, явагтун мөн миний энэ хүмүүст бошигло, учир нь тэд зүрх сэтгэлээ миний үгсийн эсрэг хатууруулсан; тэд хилэнцэт үйлүүдээ наманчилсан нь үгүй; тиймийн тул, тэдэнд би “уурандаа айлчилна, тийм ээ, тэдний алдсууд хийгээд жигшүүрт хэргүүдэд би догшин уурандаа айлчлах болно.

2 Тийм ээ, энэ үеийнхэнд халаг! Мөн Их Эзэн надад хэлэв: Гараа урагш сунгагтун мөн бошигло, хэлсэн нь: улиран тохиох дор энэ үеийнхэн өөрсдийн алдсуудын учир “боолчлолд авчрагдах болно, мөн ^бхацар дээрээ цохиулах болно; тийм ээ, хүмүүнээр хөөгдөх болно, мөн алагдах болно; мөн тэдний махбодийг нь дээр агаарт буй тас, мөн ноход, тийм ээ, мөн зэрлэг араатнууд цөлмөх болно хэмээн Их Эзэн тийн хэллээ.

3 Мөнхүү улиран тохиох дор хаан Ноагийн “амьдрал бүр халуун ^бзууханд орсон хувцас лугаа адил үнэлэгдэх болно; учир нь би бол Их Эзэн гэдгийг тэрээр мэдэх болно.

4 Мөнхүү улиран тохиох дор

би өөрийн энэ хүмүүсийг зовлонг зүдрэлүүдээр цохих болно, тийм ээ, өлсгөлөн мөн “тахлаар; мөн би тэднийг бүхэл өдрийн турш ^буйлан хайлах болгоно.

5 Тийм ээ, мөн үүрэг “ачаанууд нуруунд нь хүлэгдэхээр болгоно би; мөн тэд хэлгүй илжиг мэт туугдах болно.

6 Мөнхүү улиран тохиох дор би тэдний дунд мөндөр илгээнэ, мөн энэ нь тэднийг цохих болно; мөн тэд түүнчлэн “дорнын салхинд цохигдох болно; мөн ^бшавьжнууд тэдний нутгийг түүнчлэн зовоож, мөн тэдний үр тариаг цөлмөх болно.

7 Мөн тэд аймшигт тахлаар цохигдох болно — мөн энэ бүгдийг тэдний “алдсууд мөн жигшүүрт хэргүүдийн учир хийх болно би.

8 Мөнхүү улиран тохиох дор тэд наманчлахгүй аваас би тэднийг газрын гадаргуу дээрээс бүрмөсөн “устгах болно би; гэсэн хэдий ч тэд ^бцэдгийг ардаа орхих болно, мөн би тэднийг уг нутгийг эзэмших тэр бусад үндэстнүүдийн тул хадгалан үлдээх болно; тийм ээ, бүр би үүнийг энэ хүмүүсийн жигшүүрт хэргүүдийг бусад үндэстнүүдэд мэдүүлж болохын тулд хийх болно. Мөн энэ хүмүүсийн эсрэг олон зүйлийг Абинадай бошиглов.

12 1a Иса. 65:6.
2a Мозая 11:21; 20:21;
21:13–15; 23:21–23.
б Мозая 21:3–4.
3a Мозая 12:10.

б Мозая 19:20.
4a С ба Г 97:26.
б Мозая 21:9–10.
5a Мозая 21:3.
6a Иер. 18:17;

Мозая 7:31.
б Ег. 10:1–12.
7a С ба Г 3:18.
8a Алма 45:9–14.
б Морм. 8:14–16.

9 Мөнхүү улиран тохиох дор тэд түүнд уурлав; мөн тэд түүнийг барьж мөн хүлээд хааны өмнө аваачаад, мөн хаанд: Болгоогтун, бид таны өмнө таны хүмүүсийн талаар хилэнцтийг бошиглосон мөн Бурхан тэднийг устгах болно хэмээсэн тэр хүнийг авчирлаа гэв.

10 Мөн тэрээр түүнчлэн таны амьдралын талаар хилэнцтийг бошиглож, мөн таны амьдрал халуун зууханд орсон хувцас лугаа адил байх болно хэмээн хэлсэн бөлгөө.

11 Мөн түүнчлэн тэрээр таныг дээгүүр нь мал амьтад гүйлдэж, мөн хөл дор дэвслэгдсэн сүрэл шиг, бүр талбайд хатсан сүрэл лугаа адил байх болно хэмээв.

12 Мөн түүнчлэн, тэрээр таныг боловсорч гүйцмэгц, хэрэв салхи үлээвэл, энэ нь газрын гадаргуугаар тархах, цэцэглэж буй багваахай цэцэг лугаа адил байх болно гэж хэллээ. Мөн тэрээр Их Эзэн үүнийг ярьсан мэт дүр эсгэх ажгуу. Мөн та наманчлахгүй аваас энэ бүгд таны дээр ирэх бөгөөд энэ нь таны алдсуудын учир болой хэмээн тэрээр хэлэв.

13 Мөн эдүгээ, Ай хаантан, энэ хүнээр шүүлгэх эсвээс Бурханаар буруушаагдахаар ямар агуу хилэнц гэгчийг та хийсэн билээ, эсвээс таны хүмүүс ямар их нүглүүдийг үйлдсэн билээ?

14 Мөн эдүгээ, Ай хаантан,

болгоогтун, бид гэмгүй, та ч мөн адил, Ай хаантан, нүгэл үйлдээгүй; тиймийн тул, энэ хүн таны талаар худлаа ярьсан, мөн тэрээр хоосон бошиглосон бөлгөө.

15 Мөн болгоогтун, бид хүчирхэг, бид боолчлолд орохгүй, өөрөөр хэлбэл дайснуудаараа боолчлолд аваачигдахгүй; тийм ээ, мөн та энэ нутагт дэгжсэн, мөн та түүнчлэн дэгжих болно.

16 Болгоогтун, тэр хүн энд байна, бид түүнийг таны гарт өглөө; та өөрийн сайн гэж үзсэнийг түүнд үйлдэж болох буюу.

17 Мөнхүү улиран тохиох дор хаан Ноа Абинадайг шоронд хорихоор болгов; мөн тэрээр түүнийг яах ёстой талаар тэдэнтэй зөвлөгөөн хийж болохын тулд “санваартнуудыг цугларахыг тушаав.

18 Мөнхүү улиран тохиох дор тэд хаанд: Бид түүнийг байцааж болохын тулд түүнийг нааш авчир гэж хэлэв; мөн хаан түүнийг тэдний өмнө авчрагдах ёстой хэмээн зарлиг болов.

19 Мөн тэд түүнийг байцааж эхлэв, тэд түүнийг үүний төлөө буруутгаж болохын тулд түүний үгсийг авцалдахгүй болгоно хэмээв; гэвч тэрээр тэдэнд зоригтойгоор хариулж, мөн тэдний бүх асуултуудыг давж гаран, тийм ээ, тэдний гайхлыг төрүүлж; учир нь тэрээр тэдний бүх асуултуудыг “давж гаран, мөн

өөрсдийнх нь бүх үгсэд тэднийг ичгүүрлэсэн аж.

20 Мөнхүү улиран тохиох дор тэдний нэг нь түүнд хэлэв: Бичигдсэн буй, мөн бидний эцэг өвгөдөөр сургагдсан энэхүү үгс ямар утгатай билээ, өгүүлсэн нь:

21 Баярт мэдээнүүдийг авчирдаг; амар амгаланг тунхаглана; сайны тухай баярт мэдээнүүдийг авчирдаг; авралыг тунхагладаг; Таны Бурхан хаанчлан буй хэмээн Сионд хэлэх түүний хөл уулсын дээр “хичнээн үзэсгэлэнтэй билээ;

22 Таны харуулууд дуу хоолойгоо өргөх болно; тэд дуу хоолойгоор хамтдаа дуулна; учир нь Их Эзэн Сионыг дахин авчрахыг тэд нүдээр үзэх болно;

23 Баясацгаа; Иерусалимын ээлүүд газрууд та нар хамтдаа дуулцгаа; учир нь Их Эзэн өөрийн хүмүүсийг тайтгаруулж, тэрээр Иерусалимыг гэтэлгэсэн болой;

24 Их Эзэн өөрийн ариун “мутрыг бүх үндэстнүүдийн нүдэнд харуулсан, мөн газар дэлхийн бүх хязгаарууд Бурханы минь авралыг үзэх үү?

25 Мөн эдүгээ Абинадай тэдэнд хэлэв: Та нар “санваартнууд, мөн энэ хүмүүст сургадаг, мөн бошиглолын суу билгийг ойлгодог дүр эсгэдэг, мөн тэгсэн хэдий ч эдгээр зүйлүүд ямар утгатайг надаас мэдэхийг хүснэ гэж үү?

26 Би та нарт хэлнэ, Их Эзэний замуудыг гажуудуулсны төлөө та нарт халаг ирэг! Учир нь, хэрэв та нар эдгээр зүйлүүдийг ойлгодог бол та нар эдгээрийг сургасан нь үгүй; тиймийн тул, та нар Их Эзэний замуудыг гажуудуулжээ.

27 Та нар “ойлгохын тул зүрх сэтгэлээ зориулсангүй; тиймийн тул, та нар мэргэн байсангүй. Тиймийн тул, та нар энэ хүмүүст юу заах билээ?

28 Мөн тэд хэлэв: Бид Мосегийн хуулийг заадаг.

29 Мөн түүнчлэн тэрээр тэдэнд хэлэв: Хэрэв та нар Мосегийн “хуулийг заадаг аваас яагаад та нар үүнийг сахьдаггүй билээ? Яагаад та нар зүрх сэтгэлээ баялгуудын дээр тавих болов? Их Эзэн намайг энэ хүмүүсийн эсрэг, тийм ээ, бүр агуу хилэнцийг энэ хүмүүсийн эсрэг бошиглуулахаар илгээхэд хүргэн, та нар яагаад ^бсадар самууныг үйлдэж, мөн өөрсдийн хүчийг садар эмстэй барж, тийм ээ, мөн энэ хүмүүсийг нүгэл үйлдэхэд хүргэв?

30 Үнэнийг ярьж буйг минь та нар эс мэднэ гэж үү? Тийм ээ, би үнэнийг ярьж буйг та нар мэднэ; мөн та нар Бурханы өмнө айн чичирвэл зохилтой.

31 Мөнхүү улиран тохиох дор та нар алдсынхаа учир цохигдох болно, учир нь та нар

21а Иса. 52:7–10;

Нахум 1:15.

24а 1 Ниф. 22:11.

25а Мозая 11:5.

27а су Мэдлэг.

29а су Мосегийн хууль.

б су Завхайрал.

Мосегийн хуулийг заадаг хэмээн хэлэв. Мөн та нар Мосегийн хуулийн талаар юу мэдэх билээ? “Аврал Мосегийн хуулиар ирэх үү? Та нар юу хэлэх вэ?

32 Мөн тэд хариулж, аврал Мосегийн хуулиар ирдэг гэв.

33 Харин эдүгээ Абинадай тэдэнд хэлсэн нь: Хэрэв та нар Бурханы зарлигуудыг дагавал та нар аврагдах болно гэдгийг би мэднэ; тийм ээ, хэрэв та нар Их Эзэн “Синайн ууланд Мосед дамжуулсан энэхүү зарлигуудыг дагавал, өгүүлсэн нь:

34 “Би бол Их Эзэн чиний Бурхан, чамайг Египетийн нутгаас, боолчлолын үүрнээс ^бавчирсан тэр буюу.

35 Чи миний өмнө “өөр Бурхан байлгах ёсгүй.

36 Та нар өөрсдөдөө нэгээхэн ч зормол дүрсийг, эсвээс дээр тэнгэрт буй эсвээс доор газарт буй ямар ч зүйлийг дуурайлган хийх ёсгүй.

37 Эдүгээ Абинадай тэдэнд хэлэв, Та нар энэ бүгдийг сахьсан уу? Би та нарт хэлнэм, Үгүй, та нар тэгсэнгүй. Мөн та нар энэ хүмүүст тэд эдгээр зүйлүүдийг хийх ёстойг “сургасан уу? Би та нарт хэлнэ, Үгүй, та нар тэгээгүй.

БҮЛЭГ 13

Абинадай тэнгэрлэг хүчээр хамгаалагдав—Тэр Арван Зарлигийг

заав—Аврал зөвхөн Мосегийн хуулиар ирэхгүй—Бурхан өөрөө цагаатгал хийж мөн өөрийн хүмүүсийг гэтэлгэх болно. Ойролцоогоор мээ 148 он.

Мөн эдүгээ хаан эдгээр үгсийг сонсоод, тэрээр санваартнууддаа хэлэв: Энэ хүнийг зайлуул, мөн түүнийг хөнөө; өөрөөр хэлбэл бид түүгээр юу хийхэв, учир нь тэр галзуу юм.

2 Мөн тэд урагш босож мөн түүний дээр гараа хүрэхийг оролдов; гэвч тэрээр тэднийг эсэргүүцэж, мөн тэдэнд хэлэв:

3 Надад бүү хүр, учир нь хэрэв та нар надад гар хүрвэл Бурхан та нарыг цохих болно, учир нь дамжуулахын тулд Их Эзэн намайг илгээсэн тэрхүү мэдээг би дамжуулаагүй байна; бас надаар та нарын хэлүүлэхийг “хүссэнийг ч би хэлээгүй байна; тиймийн тул, Бурхан намайг энэ цагт устгагдахыг зөвшөөрөхгүй.

4 Харин Бурхан надад зарлигласан болгоныг би гүйцэлдүүлэх ёстой; мөн та нарт би үнэнийг хэлсэн учир та нар надад уурлах бөлгөө. Мөн түүнчлэн, би Бурханы үгийг ярьсан учир та нар намайг галзуу хэмээн шийдсэн болой.

5 Эдүгээ улиран тохиох дор Абинадай эдгээр үгсийг ярьсны дараа хаан Ноагийн хүмүүс түүнд гараа хүргэж зүрхэлсэнгүй, учир нь Их

31a Мозая 3:15; 13:27–32;
Алма 25:16.

33a Ег. 19:9, 16–20;
Мозая 13:5.

34a Ег. 20:2–4.

б Ег. 12:51;
1 Ниф. 17:40;
Мозая 7:19.

35a Хосеа 13:4.

су Хиймэл шүтээн.

37a Мозая 13:25–26.

13 3a Мозая 12:20–24.

Эзэний Сүнс түүний дээр байв; мөн түүний царай үлэмж гэрлээр, бүр Мосе Синай ууланд Их Эзэнтэй ярьж байсан үеийнхтэй адилаар “туяаран байв.

6 Мөн тэрээр Бурханаас авсан “хүч мөн эрх мэдэлтэйгээр ярьж байв; мөн тэрээр өөрийн үгсийг үргэлжлүүлж, хэлсэн нь:

7 Намайг алах хүч та нарт үгүй гэдгийг та нар харж байна, тиймийн тул би өөрийн хэлэхийг дуусгая. Тийм ээ, мөн та нарын алдсуудын талаар би та нарт үнэнийг хэлсэн учраас энэ нь та нарын зүрхэнд чинь хүртэл “зүсэж буйг би харж байна.

8 Тийм ээ, мөн миний үгс та нарыг гайхашрал мөн хачирхлаар, мөн уур хилэнгээр дүүргэх бөлгөө.

9 Гэвч би хэлэхээ дуусгая; мөн тэгээд, хэрэв би аврагдах аваас хаашаа би явах нь хамаагүй бөлгөө.

10 Харин би үүнийг та нарт хэлнэ, үүний дараа та нар намайг яах нь, тэр нь ирэх тэрхүү зүйлүүдийн “хэв шинж мөн сүүдэр байх болно.

11 Мөн эдүгээ би та нарт Бурханы “зарлигуудын үлдсэнийг нь уншъя, учир нь тэдгээр нь та нарын зүрх сэтгэлд бичигдсэн нь үгүй гэдгийг би харна; та нар амьдралынхаа ихэнх хэсэгт алдаст суралцаж мөн сургасныг би харж байна.

12 Мөн эдүгээ би та нарт: Та нар өөртөө нэгээн ч зормол дүрсийг, эсвээс дээд тэнгэрт буй эсвээс доор газарт буй, эсвээс газар доор усанд буй ямар ч зүйлийг дуурайлган хийх ёсгүй хэмээн хэлснийг та нар санаж байгаа.

13 Мөн түүнчлэн: Чи өөрийгөө тэдэнд бөхөлзүүлж, мөн тэдэнд үйлчлэх ч ёсгүй; учир нь би Их Эзэн чиний Бурхан бол хартай Бурхан, эцгүүдийнх нь алдсуудын учир хүүхдүүдийнх нь дээр, намайг үзэн ядах тэдний гурав дахь мөн дөрөв дэх үед нь хүртэл зочилно;

14 Мөн намайг хайрлах мөн миний зарлигуудыг дагах тэдний мянга мянгад нь нигүүлслийг үзүүлэх болно.

15 Чи Их Эзэн мөн Бурханыхаа нэрийг хоосноор бүү дурд; учир нь Их Эзэн түүний нэрийг хоосноор дурдах түүнийг гэмгүй хэмээн эс тооцох болно.

16 “Хүндэтгэлийн өдрийг, үүнийг ариунаар хадгалахын тулд сана.

17 Зургаан өдөр чи хөдөлмөрлөж, мөн бүх ажлаа хийх болно.

18 Харин долоо дахь өдөр, Их Эзэн Бурханыхаа хүндэтгэлийн өдөр, чи ямар ч ажил хийх ёсгүй, чи, мөн чиний хүү ч, чиний охин ч, чиний зарц ч, чиний шивэгчин ч, чиний мал сүрэг ч, мөн чиний хаалгаар

5a Ег. 34:29–35.
6a су Хүч.
7a 1 Ниф. 16:2.

10a Мозая 17:13–19;
Алма 25:10.
11a Ег. 20:1–17.

16a су Хүндэтгэлийн
өдөр.

орж ирсэн үл таних хүн ч нэгэн адил;

19 Учир нь Их Эзэн “зургаан өдөрт тэнгэр ба газрыг, мөн далайг, мөн тэдгээрийн дээрх бүхнийг хийсэн юм; тиймийн тул Их Эзэн хүндэтгэлийн өдрийг адисалсан, мөн үүнийг ариулсан болой.

20 Их Эзэн Бурхан тань чамд өгсөн тэр нутаг дээр чиний өдрүүд урт байж болохын тулд Эцэг, эхээ “хүндэл.

21 Чи хүн бүү “ал.

22 Чи “садар самууныг үйлдэх ёсгүй. Чи ^бхулгайлах ёсгүй.

23 Чи хөршийнхөө эсрэг “хуурамчаар гэрчлэх ёсгүй.

24 Чи хөршийнхөө байшинд “шунах ёсгүй, чи хөршийнхөө эхнэрт, бас түүний зарцад, түүний шивэгчинд ч, түүний шар, түүний илжиг, хөршийнх чинь болох юунд ч шунах ёсгүй.

25 Мөнхүү улиран тохиох дор Абинадай эдгээр үгээ төгсгөл болгосны дараа тэрээр тэдэнд хэлэв: Эдгээр зарлигуудыг дагахын тулд тэд эдгээр бүх зүйлийг хийхээр чармайх ёстойг та нар энэ хүмүүст заасан гэж үү?

26 Би та нарт хэлнэ, Үгүй; учир нь хэрэв та нар тэгсэн

бол, Их Эзэн намайг энд ирүүлж мөн энэ хүмүүсийн талаар хилэнцтийг бошигдуулахгүй байх байсан.

27 Мөн эдүгээ та нар Мосегийн “хуулиар аврал ирнэ хэмээн хэллээ. Одоогоор Мосегийн хуулийг дагах ёстой нь зайлшгүйг би та нарт хэлбэ; гэвч би та нарт хэлнэ, Мосегийн хуулийг дагах нь ^бцаашид зайлшгүй байхаа болих тэр цаг ирэх болно.

28 Мөн үүнээс гадна би та нарт хэлнэ, “аврал зөвхөн ^бхуулиар ирэх нь үгүй; мөн Бурхан өөрийн хүмүүсийн нүглүүд хийгээд алдсуудын учир өөрөө хийх тэрхүү “цагаатгал үгүй аваас Мосегийн хууль байлаа ч, тэд гарах аргагүйгээр мөхөх ёстой болно.

29 Мөн эдүгээ би та нарт хэлнэ, Израилын хүүхдүүдэд хууль өгөгдөх нь зайлшгүй байв, тийм ээ, бүр маш “хатуу хууль; учир нь тэд зөрүүд хүмүүс, алдсыг үйлдэхдээ ^бхурдан, мөн Их Эзэн Бурханаа санахдаа хойрго байсан болой;

30 Тиймийн тул тэдэнд “хууль өгөгдсөн байв, тийм ээ, гүйцэтгэлүүдийн хийгээд ^бёслолуудын хууль, Бурханыг

19a Эхл. 1:31.

20a Марк 7:10.

21a Мат. 5:21–22;

С ба Г 42:18.

су Аллага.

22a су Завхайрал.

б су Хулгай хийх,

Хулгай.

23a Сур. үгс 24:28.

су Худал хэлэх.

24a су Шунах.

27a су Мосегийн хууль.

б 3 Ниф. 9:19–20;

15:4–5.

28a Гал. 2:16.

су Гэтэлгэх,

Гэтэлгэгдэх,

Гэтэлгэл; Аврал.

б Гал. 2:21;

Мозая 3:14–15;

Алма 25:15–16.

в су Цагаатгах,

Цагаатгал.

29a Иош. 1:7–8.

б Алма 46:8.

30a Ег. 20.

б су Ёслолууд.

мөн түүний өмнө хүлээсэн өөрсдийнх нь үүргийг тэдэнд сануулж байхын тулд, тэд өдрөөс өдөрт чандаар “мөрдөх ёстой тэрхүү хууль болой.

31 Гэвч болгоогтун, би та нарт хэлнэ, эдгээр бүх зүйл ирэх зүйлүүдийн “хэв шинж байв.

32 Мөн эдүгээ, тэд хуулийг ойлгосон уу? Би та нарт хэлнэ, Үгүй, тэд бүгд хуулийг ойлгосон нь үгүй; мөн энэ нь тэдний зүрх сэтгэлийн хатуугийн учир болой; учир нь тэд Бурханы гэтэлгэлийн “гадуур аваас хэн боловч аврагдаж чадахгүйг ойлгосонгүй.

33 Учир нь болгоогтун, Мессиагийн ирэлтийн талаар, мөн Бурхан өөрийн хүмүүсийг гэтэлгэх ёстойг Мосе тэдэнд бошиглоогүй гэж үү? Тийм ээ, мөн дэлхий эхэлснээс хойш бошиглож асан бүр “бүх бошиглогчид—тэд эдгээр зүйлийн талаар их бага боловч ярьсан бус уу?

34 Тэд “Бурхан өөрөө хүмүүний үрсийн дунд доош ирж, мөн хүний хэлбэрийг өөртөө авч, мөн газрын гадаргуу дээр их хүчтэйгээр урагшлан явахыг тэд хэлсэн бус уу?

35 Тийм ээ, мөн түүнчлэн тэрээр үхэгсдийн “амилуулалтыг улируулан тохиолгож, мөн тэр, өөрөө, хавчигдан мөн зовоогдох ёстойг тэд хэлсэн бус уу?

БҮЛЭГ 14

Исаиа Мессиагийн талаар яриу — Мессиа доромжлогдох нь мөн зовлонгууд нь яригдав — Тэрээр өөрийн бодгалийг нүглийн төлөө өргөл болгон мөн зөрчигчдийн төлөө өмгөөллийг санал болгох болно — Исаиагийн 53 дугаар бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мээ 148 он.

Тийм ээ, бүр Исаиа хэлсэн бус уу: Хэн бидний цэдэгт итгэж, мөн хэнд Их Эзэний мугар илчлэгдсэн билээ?

2 Учир нь тэрээр түүний өмнө зулзаган нахиа мэт мөн хуурай газраас гарах үндэс лугаа адил ургах болно; тэрээр онцгой хэлбэр мөн гоо сайхан ч үгүй байна; мөн бид түүнийг харахад бид түүнийг хүсмээр сайхан нь түүнд үгүй байх болно.

3 Тэрээр хүмүүнээр гадуурхагдаж мөн үл тоомсорлогдсон болно; харамсагч нэгэн мөн гашуудлыг танин мэдсэн бөлгөө; мөн бид түүнээс нүүрээ нуусан мэт байх болно; тэрээр гадуурхагдаж, мөн бид түүнийг хүндэтгэх нь үгүй.

4 Гарцаагүй тэр бидний “гашуудлыг ^бхүлээн авч, мөн бидний харамслыг үүрсэн; гэсэн хэдий ч бид түүнийг шаналсан, Бурханаар цохигдсон, мөн зовоогдсон хэмээн бодох болно.

30в Иаков 4:5.

31а Мозая 16:14;

Алма 25:15.

сү Бэлэгдлийн.

32а 2 Ниф. 25:23–25.

33а 1 Ниф. 10:5;

Иаков 4:4; 7:11.

34а Мозая 7:27; 15:1–3.

сү Бурхан, Бурхан тэргүүтэн.

35а Иса. 26:19;

2 Ниф. 2:8.

14 аа Мат. 8:17.

б Алма 7:11–12.

5 Гэвч тэрээр бидний “зөрчлүүдийн төлөө шархадна, тэрээр бидний алдсуудын төлөө зодуулан хөх няц болно; бидний амгалангийн төлөөс түүний дээр байх болно; мөн түүний шархны судлаар бид ^банагаагдах буюу.

6 Бид бүгд, “хонь лугаа адил, төөрч одсон; бид нэг бүрээрээ өөрийн замыг хөөж одсон; мөн бид бүгд өөрсдийн алдсуудыг Их Эзэн түүний дээр үүрүүлэх болно.

7 Тэрээр хавчигдсан байна, мөн тэрээр зовоогдсон байна, гэвч “тэрээр ам нээх нь үгүй; нядалгааны газар тэр ^бхурга мэт авчрагдан, мөн ноос хяргагчийн өмнө хонь хэлгүй байдаг мэт, тэрчлэн тэрээр ам үл нээх болно.

8 Тэрээр шоронгоос мөн шүүлтээс авагдсан буюу; мөн хэн түүний үе удмыг тунхаглах билээ? Учир нь тэрээр амьдын ертөнцөөс тусгаарлагдсан байв; тэрээр миний хүмүүсийн зөрчлүүдийн улмаас зовсон бөлгөө.

9 Мөн тэрээр өөрийн булшийг ёс бусыг үйлдэгчидтэй нэг дор байлгав, мөн үхэлдээ “баячуудтай нэг дор байв; тэрбээр ^бхилэнц үйлдсэнгүйн учир, мөн түүний аманд заль мэх байсангүйн учир буюу.

10 Гэвч тэрээр зодуулан хөхрөх нь Их Эзэний таалалд нийцсэн юм; тэрээр түүнийг гашуудалд умбуулсан; та нар түүний бодгалийг нүглийн төлөөс болгоход тэрээр “үр удмаа харах болно, тэрээр өөрийн өдрүүдийг уртасгаж, мөн Их Эзэний таалал түүний гарт дэгжих болно.

11 Тэрээр бодгалийнхаа тарчлалыг харах болно, мөн сэтгэл хангагдах болно; миний зөв шударга үйлчлэгч олныг мэдлэгээрээ зөвтгөх болно; учир нь тэрээр тэдний алдсуудыг “үүрэлцэх болно.

12 Тиймийн тул би түүнд агуу ихсүүдтэй адил хувийг оногдуулж, мөн тэрээр хүчтэнүүдтэй адил олзыг хуваалцана; учир нь тэр сүнсээ үхэх хүртлээ юүлсэн билээ; мөн тэрбээр зөрчигчидтэй хамт тоологдсон; мөн тэрээр олны нүглийг үүрэлцэж, мөн зөрчигчдэд “өмгөөлөл үйлдсэн бөлгөө.

БҮЛЭГ 15

Христ Эцэг мөн Хүү аль аль нь хэрхэн байдаг вэ—Тэрээр өмгөөлөл үйлдэж мөн өөрийн хүмүүсийн зөрчлүүдийг үүрэлцэх болно—Тэд болон ариун бошиглогчид түүний үр удам

5a Мозая 15:9;

Алма 11:40.

б 1 Петр 2:24–25.

6a Мат. 9:36;

2 Ниф. 28:14;

Алма 5:37.

7a Марк 15:3.

су Есүс Христ.

б су Бурханы Хурга;

Дээгүүр Өнгөрөх.

9a Мат. 27:57–60;

Марк 15:27, 43–46.

су Арматиагийн

Иосеф.

б Иохан 19:4.

10a Мозая 15:10–13.

11a Лев. 16:21–22;

1 Петр 3:18;

С ба Г 19:16–19.

12a 2 Ниф. 2:9;

Мозая 15:8;

Моро. 7:27–28.

мөн — Тэрээр Амилуулалтыг улируулан тохиох болгосон бөлгөө — Бяцхан хүүхдүүдэд мөнх амьдрал байдаг. Ойролцоогоор мээ 148 он.

Мөн эдүгээ Абинадай тэдэнд хэлэв: “Бурхан өөрөө хүмүүний үрсийн дунд доош ирэх болно, мөн өөрийн хүмүүсийг ^бгэтэлгэх болно гэдгийг та нар ойлгоосой хэмээнэ би.

2 Мөн тэрээр маханбодид “оршихын учир тэрээр Бурханы Хүү гэж нэрлэгдэх болно, мөн Эцэгийн тааллын дагуу маханбодийг харьяалуулсны учир, ^бЭцэг мөн Хүү байдаг —

3 Эцэг, “учир нь тэр Бурханы хүчээр ^ббий болгогдсон билээ; мөн Хүү, маханбодийнхоо учир буюу; ийн Эцэг бас Хүү болдог —

4 Мөн тэд бол “нэг Бурхан, тийм ээ, тэнгэр ба газрын чухамхүү тэр ^бМөнхийн “Эцэг.

5 Мөн тийн маханбодь Сүнсний харьяат болж, өөрөөр хэлбэл Хүү нь Эцэгийн харьяат болох учир, нэг Бурхан тул, уруу таталтыг “тэвчдэг, мөн уруу таталтанд үл автагддаг, гэсэн ч өөрийгөө доромж-

логдохыг, мөн ^бцээрлүүлэгдэхийг, мөн хөөгдөхийг, мөн өөрийн хүмүүсээр ^бэс үнэлэгдэхийг тэвчих бөлгөө.

6 Мөн энэ бүгдийн дараа, хүмүүний үрсийн дунд олон хүчит гайхамшиг үйлдсэнийхээ дараа, тэрээр хөтлөгдөх болно, тийм ээ, бүр “Исаиагийн хэлсэнчлэн, ноос хяргагчийн өмнө хонь хэлгүй лугаа адил байдаг шиг, тэрчлэн тэрбээр амаа ^бүл нээх болно.

7 Тийм ээ, бүр тийн тэр хөтлөгдөн, “цовдлогдон, мөн хөнөөгдөх болно, уг маханбодь бүр үхлийн харьяат болж, Хүүгийн ^бтаалал Эцэгийн таалалд багтах бөлгөө.

8 Мөн Бурхан ийн үхлийн “хүлээсийг тасчина, учир нь тэр үхлийг даван ^бялалтыг олно; мөн тэрээр Хүүд хүмүүний үрсийн төлөө ^бөмгөөлөл хийх хүчийг өгнө —

9 Тэнгэрт одсон, нигүүлслийн зүрхтэй байна; мөн тэрээр хүмүүний үрсэд хандсан нинжин сэтгэлээр дүүргэгдсэн байна; мөн тэрээр тэдний мөн шударга ёсны хооронд зогсдог бөлгөө; үхлийн хүлээсийг тасчиж, “өөр дээрээ

15 1а 1 Тим. 3:16;
Мозая 13:33–34.

су Есүс Христ.

б су Гэтэлгэх,

Гэтэлгэгдэх,

Гэтэлгэл.

2а Мозая 3:5; 7:27;

Алма 7:9–13.

б Иса. 64:8;

Иохан 10:30; 14:8–10;

Мозая 5:7;

Алма 11:38–39;

Ифер 3:14.

3а С ба Г 93:4.

б Лук 1:31–33;

Мозая 3:8–9;

Алма 7:10;

3 Ниф. 1:14.

4а Дэд хууль 6:4;

Иохан 17:20–23.

су Бурхан, Бурхан

тэргүүтэн.

б Алма 11:39.

в Мозая 3:8; Хил. 14:12;

3 Ниф. 9:15;

Ифер 4:7.

5а Лук 4:2; Евр. 4:14–15.

б Иохан 19:1.

в Марк 8:31;

Лук 17:25.

6а Иса. 53:7.

б Лук 23:9;

Иохан 19:9;

Мозая 14:7.

7а су Цовдлуулалт.

б Лук 22:42;

Иохан 6:38;

3 Ниф. 11:11.

8а Мозая 16:7;

Алма 22:14.

б Хосеа 13:14;

1 Кор. 15:55–57.

в 2 Ниф. 2:9.

9а Иса. 53;

Мозая 14:5–12.

тэдний алдас мөн тэдний зөрчлүүдийг авч, тэднийг гэтэлгэн, мөн шударга ёсны шаардлагыг ^бхангах буюу.

10 Мөн эдүгээ би та нарт хэлнэ, түүний үе удмыг хэн тунхаглах билээ? Болгоогтун, би та нарт хэлье, түүний бодгаль нүглийн төлөөс болсон байхад тэрээр өөрийн “үрсийг харах болно. Мөн эдүгээ та нар юу хэлэх вэ? Мөн хэн түүний үр удам байх билээ?

11 Болгоогтун би та нарт хэлнэ, “бошиглогчдын үгсийг сонссон хэн боловч, тийм ээ, Их Эзэний ирэлтийн талаар бошиггосон бүх ариун бошиглогчид — би та нарт хэлнэ, тэдний үгсийг сонсож анхаарсан хэн боловч бүгд мөн Их Эзэн өөрийн хүмүүсийг гэтэлгэх болно хэмээн итгэсэн, мөн нүглүүдийнхээ ангижралын төлөө тэр өдрийг харуулдан хүлээсэн нь, би та нарт хэлье, эд бол түүний үр удам, өөрөөр хэлбэл тэд бол Бурханы ^бхаант улсыг өвлөгчид юм.

12 Учир нь “тэрээр нүглийг нь үүрсэн тэд бол эдгээр болой; эдгээр нь өөрсдийнх нь зөрчлүүдээс тэднийг гэтэлгэхийн тулд наснаас хальсан тэд болой. Мөн эдүгээ, тэд түүний үр удам бус уу?

13 Тийм ээ, мөн бошиглогчид ч тийм бус уу? Бошигло-

хын тулд амаа нээсэн болон зөрчилд унаагүй, дэлхий эхэлсэн цагаас хойших бүх ариун бошиглогчдыг би хэлж байна. Тэд бол түүний үр удам гэдгийг би та нарт хэлнэ.

14 Мөн эдгээр нь амар амгаланг “зарласан тэд, сайны тухай баярт мэдээг авчирсан тэд, авралыг зарласан тэд бөлгөө; мөн Сионд хэлсэн нь: Таны Бурхан хаанчлан буй!

15 Мөн, Ай уулсын дээрх тэдний хөл хичнээн үзэсгэлэнтэй байсан билээ!

16 Мөн түүнчлэн, амар амгаланг зарласаар буй тэдний хөл уулсын дээр хичнээн үзэсгэлэнтэй билээ!

17 Мөн түүнчлэн, хожим амар амгаланг зарлах тэдний хөл уулсын дээр хичнээн үзэсгэлэнтэй билээ, тийм ээ, энэ цагаас хойшид мөн үүрд!

18 Мөн болгоогтун, би та нарт хэлье, энэ бол бүгд биш. Учир нь “амар амгаланг үндэслэгч нь болсон тэр, баярт мэдээг авчрах түүний ^бхөл уулсын дээр хичнээн үзэсгэлэнтэй билээ, тийм ээ, бүр Их Эзэн, өөрийн хүмүүсийг гэтэлгэсэн тэрбээр; тийм ээ, өөрийн хүмүүст авралыг хайрласан тэрбээр;

19 Учир нь өөрийн хүмүүсийн төлөө түүний хийсэн, дэлхийн “үүслээс бэлтгэгдсэн

9б су Цагаатгах,
Цагаатгал.

10а Иса. 53:10;
Мозая 5:7; 27:25;
Моро. 7:19.

11а С ба Г 84:36–38.

б су Бурханы хаант

улс буюу Тэнгэрийн
хаант улс; Аврал.

12а Мозая 14:12;
Алма 7:13; 11:40–41.

14а Иса. 52:7;
Ром 10:15;

1 Ниф. 13:37;

Мозая 12:21–24.

су Номлолын ажил.

18а Иохан 16:33.

су Амар амгалан.

б З Ниф. 20:40;

С ба Г 128:19.

19а Мозая 4:6.

тэрхүү гэтэлгэл үгүй байсан аваас, би та нарт хэлнэ, энэ нь үгүй байсан аваас, бүх хүн төрөлхтөн ^бмөхөх ёстой байсан бөлгөө.

20 Гэвч болгоогтун, үхлийн хүлээс тасчигдах болно, мөн Хүү хаанчилна, мөн үхэгсдийн дээр хүчтэй байх буюу; тиймийн тул, тэрээр үхэгсдийн амилуулалтыг улируулан тохиолгох бөлгөө.

21 Мөн амилуулалт ирнэ, бүр “анхны амилуулалт; тийм ээ, бүр байсны, байгаагийн, бүр Христийн амилуулалтыг хүртэл байх тэдний амилуулалт — учир нь тийн тэрээр нэрлэгдэх бөлгөө.

22 Мөн эдүгээ, бүх бошиглогчдын мөн тэдний үгсэд итгэсэн тэд бүгдийн, өөрөөр хэлбэл Бурханы зарлигуудыг дагасан тэд бүгдийн амилуулалт, анхны амилуулалтаар босч ирэх болно; тиймийн тул, тэд бол анхны амилуулалт юм.

23 Тэд өөрсдийг нь гэтэлгэсэн Бурхантай хамт “оршихоор өргөмжлөгддөг буюу; тийн үхлийн хүлээсийг ^бтасчсан Христээр дамжин тэд мөнх амьдралтай болох болно.

24 Мөн тэд бол анхны амилуулалтанд байр эзлэх тэд болой; мөн тэд бол Христийг ирэхээс өмнө, өөрсдийн мэ-

дэхгүйд, “аврал тэдэнд тунхаглагдаагүйгээр нас барсан тэд бөлгөө. Мөн тийн Их Эзэн тэдний сэргээлтийг авчрах болно; мөн тэд анхны амилуулалтанд байр эзэлж өөрөөр хэлбэл мөнх амьдралтай байна, учир нь тэд Их Эзэнээр гэтэлгэгдсэн болой.

25 Мөн түүнчлэн бяцхан “хүүхдүүдэд мөнх амьдрал буй.

26 Гэвч болгоогтун, мөн “эмээгтүн, мөн Бурханы өмнө чичрэгтүн, учир нь та нар чичрэх нь зохистой; учир нь Их Эзэн өөрийг нь ^бэсэргүүцэх мөн нүглүүддээ “үхэх хэнийг боловч үл гэтэлгэнэ; тийм ээ, бүр дэлхий эхэлснээс хойш нүгэлдээ мөхсөн тэд, Бурханыг санаатайгаар эсэргүүцсэн тэд, Бурханы зарлигуудыг мэдэх мөртлөө, тэдгээрийг дагахгүй байсан тэд бүгд; тэд бол анхны амилуулалтанд ^абайр эзлэхгүй тэд болой.

27 Тиймийн тул та нар чичрэх нь зохистой бус уу? Учир нь аврал иймүүдийн нэгэнд нь ч ирэхгүй; учир нь Их Эзэн иймүүдийн нэгийг нь ч гэтэлгээгүй; тийм ээ, Их Эзэн иймүүдийг гэтэлгэж чадахгүй; учир нь тэр өөрийгөө үгүйсгэж чадахгүй; учир нь “шударга ёс эрхээ эдлэх үед тэрээр үүнийг үгүйсгэж чадахгүй.

19б 2 Ниф. 9:6–13.

21а Алма 40:16–21.

23а Дуул. 24:3–4;

1 Ниф. 15:33–36;

С ба Г 76:50–70.

б су Биенийн үхэл.

24а 2 Ниф. 9:25–26;

С ба Г 137:7.

25а С ба Г 29:46; 137:10.

су Аврал —

Хүүхдүүдийн аврал.

26а Дэд хууль 5:29;

Иаков 6:9.

б 1 Ниф. 2:21–24.

в Езек. 18:26;

1 Ниф. 15:32–33;

Моро. 10:26.

г Алма 40:19.

д С ба Г 76:81–86.

27а Алма 34:15–16; 42:1.

28 Мөн эдүгээ би та нарт хэлнэ, Их Эзэний аврал бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүст “тунхаглагдах тэр цаг ирэх болно.

29 Тийм ээ, Их Эзэн, таны “харуулууд дуу хоолойгоо өргөн; тэд нэгэн дуу хоолойгоор хамтдаа дуулах болно; учир нь тэд Их Эзэн Сионыг дахин авчрахыг нүдээр үзэх болно.

30 Баясацгаа, хамтдаа дуулдаг, Иерусалимын эзгүй газрууд аа; учир нь Их Эзэн өөрийн хүмүүсийг тайтгаруулсан, тэрээр Иерусалимыг гэтэлгэсэн бөлгөө.

31 Их Эзэн ариун мутраа бүх үндэстнүүдийн нүдэнд харуулна; мөн газар дэлхийн бүх хязгаарууд бидний Бурханы авралыг харах болно.

БҮЛЭГ 16

Бурхан хүмүүсийг төөрөлдсөн хийгээд унасан байдлаас нь гэтэлгэдэг—Эгэл байдалтай тэд гэтэлгэл үгүй мэтээр үлдэх болно—Христ төгсгөлгүй амьдралд орох эсвээс төгсгөлгүй ялд орох амилуулалтыг улируулан тохиолгодог. Ойролцоогоор мээ 148 он.

Мөн эдүгээ, улиран тохиох дор Абинадай эдгээр үгийг

ярьсныхаа дараа тэр гараа урагш сунган мөн хэлэв: Бүгд Их Эзэний “авралыг харна; үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс бүгд нүдээрээ үзнэ, мөн Бурханы өмнө түүний шүүлтүүд шударгыг ^бхүлээх тэр цаг ирэх болно.

2 Мөн тэгээд ёсон бусыг үйлдэгчид “зайлуулагдаж, мөн тэд гаслах, мөн ^буйлах, мөн орилох, мөн шүдээ хавирах шалтгаан бүхий болно; мөн тэд Их Эзэний дуу хоолойг анхааран сонсохгүй байсны учир бөлгөө; тиймийн тул Их Эзэн тэднийг гэтэлгэх нь үгүй.

3 Учир нь тэд “эгэл мөн чөтгөр мэт, мөн ^бчөтгөр тэднийг давах хүчтэй; тийм ээ, бүр бидний анхны эцэг эхийг ^амэхэлсэн, тэднийг ‘уналтанд хүргэсэн тэр хөгшин хорт могой; бүх хүн төрөлхтний маханбодийг эгэл, тачаангуй, чөтгөр мэт, сайнаас мууг ^аялгаж мэдэх болгосны, өөрсдийгөө чөтгөрийн харьяат болгосны шалтгаан байсан тэр буюу.

4 Тийн бүх хүн төрөлхтөн “төөрөлдсөн бөлгөө; мөн болгоогтун, Бурхан өөрийнхөө хүмүүсийг төөрөлдсөн мөн унасан байдлаас нь гэтэлгээгүй сэн бол тэд төгсгөлгүйгээр төөрөлдөх байсан буйза.

28а су Номлолын ажил.

29а су Харах, Харуул.

16 1а су Аврал.

б Мозая 27:31.

2а С ба Г 63:53–54.

б Мат. 13:41–42;

Лук 13:28;

Алма 40:13.

3а Гал. 5:16–25;

Мозая 3:19.

су Эгэл хүн.

б 2 Ниф. 9:8–9.

су Чөтгөр.

в Эхл. 3:1–13;

Моце 4:5–19.

г су Адам Ева хоёрын Уналт.

д 2 Ниф. 2:17–18, 22–26.

4а Алма 42:6–14.

5 Гэвч өөрийн “эгэл чанартаа хэвээр үлдэж мөн нүглийн хийгээд Бурханыг эсэргүүцэх замуудаар явсаар байдаг тэрээр, унасан байдалдаа үлдэж мөн чөтгөр түүнийг давах бүхий л хүчтэй байна. Тиймийн тул тэрээр ⁶гэтэлгэл хийгдсэнгүй мэт, Бурханы дайсан байдаг учир; мөн түүнчлэн чөтгөр бол Бурханы дайсан бөлгөө.

6 Мөн эдүгээ хэрэв Христ дэлхийд ирээгүй аваас, ирэх зүйлүүдийг “аль хэдийн ирсэн мэт яривал, гэтэлгэл байж чадахгүй сэн билээ.

7 Мөнхүү хэрэв Христ үхэгсдийн дундаас босоогүй сэн бол, өөрөөр хэлбэл булш нь ялалт үгүй байж мөн үхэл нь “гашуун бус байхын учир, үхлийн хүлээсийг тасчаагүй сэн бол, амилуулалт гэж үгүй байх сан.

8 Гэвч “амилуулалт буй, тиймийн тул булшинд ялалт гэж үгүй, мөн ⁶үхлийн гашуун нь Христээр залгигдсан юм.

9 Тэр бол дэлхийн “гэрэл хийгээд амь амьдрал болой; тийм ээ, хэзээ ч харанхуйлагдахгүй төгсгөлгүй тэрхүү гэрэл; тийм ээ, мөн түүнчлэн үхэл гэж цаашид байж үл болох, төгсгөлгүй амь амьдрал болой.

10 Бүр энэ зуурдын бие “үхэшгүй байдлыг өмсөж, мөн энэ ялзрал ялзаршгүй байдалд тавигдах болно, мөн Бурханы тавцангийн өмнө ⁶зогсон, тэдгээр нь сайн ч бай, эсвэл тэдгээр нь хилэнцэт ч бай, үйлүүдийнхээ дагуу түүнд ⁶шүүгдэхээр авчрагдах болно—

11 Хэрэв тэдгээр нь сайн байх аваас, “төгсгөлгүй амьдралын мөн аз жаргалын амилуулалтанд; мөн хэрэв тэдгээр нь хилэнцэт байх аваас ⁶төгсгөлгүй ялын амилуулалтанд, тэднийг харьяалах чөтгөрт илгээгдэх тул, ял гэдэг нь тэр букуу—

12 Өөрсдийн эгэл тааллууд мөн хүслүүдийн дагуу явсан учир; нигүүлслийн мутар нь тэдний зүг сунгагдсан үед Их Эзэнийг хэзээ ч дуудаагүй учир; тодруулбал “нигүүлслийн мутар тэдний зүг сунгаастай байсан, мөн тэд хүссэнгүй; тэд алдсуудынхаа талаар сэрэмжлүүлэгдсэн ч, тэд тэдгээрээс хагацсан нь үгүй бөлгөө; мөн тэд наманчлахыг зарлигдуулсан боловч тэд наманчлахгүй байлаа.

13 Мөн эдүгээ, та нар чичирч мөн нүглээ наманчлан, мөн зөвхөн Христэд мөн түүгээр дамжуулан та нар аврагдаж

5a Алма 41:11.
су Тачаангуй,
Зуурдын.
б су Гэтэлгэх,
Гэтэлгэгдэх,
Гэтэлгэл.
6a Мозая 3:13.
7a Хосеа 13:14;
Мозая 15:8, 20.

8a Алма 42:15.
су Амилуулалт.
б Иса. 25:8;
1 Кор. 15:54–55;
Морм. 7:5.
9a С ба Г 88:5–13.
су Гэрэл, Христийн
гэрэл.
10a Алма 40:2.

су Мөнх бус, Мөнх
бус байдал.
б су Эцсийн шүүлт.
в Алма 41:3–6.
11a су Мөнх амьдрал.
б су Ял.
12a су Нигүүлсэнгүй,
Нигүүлсэл.

чадна гэдгийг санах нь зохистой бус уу?

14 Тиймийн тул, хэрэв та нар Мосегийн “хуулийг заана гэвэл, түүнчлэн энэ нь ирэх зүйлүүдийн дүрслэл гэдгийг заагтун—

15 Тэдэнд гэтэлгэл нь чухам “Мөнхийн Эцэг болох Христ Их Эзэнээр дамжин ирэхийг сургагтун. Амен.

БҮЛЭГ 17

Алма Абинадайн үгсэд итгэж мөн бичиглэв—Абинадай шатаагдах үхлийг амсав—Тэрээр өөрийн алуурчид дээр өвчнийг мөн шатаагдах үхлийг бошиглов. Ойролцоогоор мээ 148 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Абинадай эдгээр үгээ дуусгахад, “санваартнууд түүнийг барьж мөн тэр үхэлд хүргэгдэх ёстой хэмээн хаан зарлиг болгосон бөлгөө.

2 Гэвч тэдний дунд “Алма гэж нэрлэгдсэн нэгэн байв, түүнчлэн тэр Нифайн удам байлаа. Мөн тэрээр залуу хүн байж, мөн Абинадайн ярьсан үгсэд “итгэжээ, учир нь тэрээр тэдний эсрэг Абинадайн гэрчилсэн алдсын талаар мэдэж байв; тиймийн тул тэрээр Абинадайд уурлахгүй байхыг, харин түүнийг амар амгалан явуулахыг зөвшөөрөхийг хаанаас гуйж эхлэв.

3 Гэвч хаан илүүтэй хилэгнэж, мөн Алмаг тэдний

дундаас зайлуулагдах болгов, мөн тэд түүнийг алж болохын тулд зарц нараа түүний араас илгээсэн бөлгөө.

4 Гэвч тэр тэдний өмнө зугтан мөн өөрийгөө нуусан учир тэд түүнийг олсонгүй. Мөн тэрээр олон өдөр нуугдаж байсан учир Абинадайн ярьсан бүх үгсийг “бичиглэв.

5 Мөнхүү улиран тохиох дор хаан харуулуудаараа Абинадайг бүслүүлэн мөн баривчлуулав; тэгээд тэд түүнийг хүлж, шоронд хаяв.

6 Мөн гурав хоногийн дараа, санваартнуудтайгаа зөвлөсний дараа, тэрээр түүнийг өөрийнхөө өмнө дахин авчруулав.

7 Мөн тэрээр түүнд хэлэв: Абинадай, бид чиний эсрэг буруушаалтыг оллоо, тэгэхлээр чи үхвэл зохино.

8 Учир нь “Бурхан өөрөө хүмүүний үрсийн дунд доош ирэх болно хэмээн чи хэлсэн; мөн эдүгээ, үүний улмаас чи миний болон миний хүмүүсийн талаар хилэнцтийг ярьсан тэр бүх үгээ буцаахгүй аваас чи үхэлд хүргэгдэх болно.

9 Эдүгээ Абинадай түүнд хэлэв: Би танд хэлнэ, би энэ хүмүүсийн талаар та нарт ярьсан үгсээ буцаах нь үгүй, тэдгээр нь үнэн учир; мөн та нар тэдгээрийг гарцаагүй гэдгийг мэдэж болохын тулд би өөрийгөө та нарын гарт орохыг хүлцсэн бөлгөө.

14а су Мосегийн хууль.
15а Мозая 3:8; 5:7;
Ифер 3:14.

17 1а Мозая 11:1, 5–6.
2а Мозая 23:6, 9–10.
су Ахмад Алма.

б Мозая 26:15.
4а су Судрууд.
8а Мозая 13:25, 33–34.

10 Тийм ээ, мөн би бүр үхэлд хүртэл зовох болно, мөн би өөрийн үгсийг буцаахгүй, бас тэдгээр нь та нарын эсрэг гэрчлэл болон зогсох болно. Мөн хэрэв та нар намайг албал та нар “гэмгүй цусыг урсгах болно, мөн энэ нь түүнчлэн эцсийн өдөр та нарын эсрэг гэрчлэл болж зогсох болно.

11 Мөн эдүгээ хаан Ноа түүний үгнээс айсан учир түүнийг суллах дөхөв; учир нь Бурханы шүүлтүүд өөр дээр нь ирэх вий хэмээн тэр айсан ажээ.

12 Гэвч санваартнууд түүний эсрэг дуугаа өндөрсгөн, мөн түүнийг буруутгаж эхлэв, өгүлсэн нь: Тэр хааныг доромжилсон. Тиймийн тул хаан түүний эсрэг уурандаа бачуурч, мөн тэрээр түүнийг хөнөөгдөж болохын тулд илгээв.

13 Мөнхүү улиран тохиох дор тэд түүнийг барьж мөн хүлээд, мөн арьсыг нь саваагаар, тийм ээ, бүр үхтэл нь ороолгов.

14 Мөн эдүгээ дөл түүнийг түлж эхлэхэд, тэрээр тэдэнд хашгирч, өгүүлсэн нь:

15 Болгоогтун, та нар намайг ингэсний тань адил, үүнчлэн улиран тохиох дор та нарын үр удам миний тэвчсэн өвчнийг, бүр галд шатаагдаж “үхэхийн зовлонг олонд мэдрүүлэх болно; мөн тэд Их Эзэн Бурханыхаа авралд итгэдэг учраас болой.

16 Мөнхүү улиран тохиох дор та нар алдсуудынхаа улмаас төрөл бүрийн өвчний улмаас зовоогдох болно.

17 Тийм ээ, мөн та нар тал бүрээсээ “цохигдох болно, мөн нааш цааш бусниулагдаж мөн туугдах болно, бүр зэрлэг мөн догшин араатнуудад зэрлэг сүрэг туугддаг лугаа адил байх болно.

18 Мөн тэр өдөр та нар ангуучлагдах болно, мөн та нар дайснуудынхаа гараар баривчлагдах болно, мөн тэгээд та нар зовж, миний зовж буйн адил, шатаагдан “үхэхийн өвдөлтөөр зовох болно.

19 Ийн Бурхан өөрийнх нь хүмүүсийг устгах тэдний дээр “өс хонзонгоо хэрэгжүүлдэг болой. Ай Бурхан минь, бодгалийг минь хүлээн аваач.

20 Мөн эдүгээ, Абинадай эдгээр үгийг хэлээд, тэр унав, шатаагдаж үхэхийн зовлонг амссан ажгуу; тийм ээ, тэрээр Бурханы зарлигуудыг үгүйсгэхгүйн тулд үхэлд тушаагдсан байв, өөрийн үгсийн үнэнийг амиараа лацдан баталжээ.

БҮЛЭГ 18

Алма нууцаар номлов—Тэрээр баптисмын гэрээг тайлбарлаж мөн Мормоны Усанд баптисм хүртээв—Тэрээр Христийн сүм байгуулж мөн санваартнуудыг томилов—Тэд өөрсдөө бие даан амьдарч мөн хүмүүст сургав—

Алма мөн түүний хүмүүс Хаан Ноагаас аглаг буйдад зугтав. Ойролцоогоор мээ 147–145 он.

Мөн эдүгээ, улиран тохиох дор хаан Ноагийн зарц нараас зугтсан Алма, өөрийн нүглүүд хийгээд алдсуудаа “наманчлав, мөн хүмүүсийн дунд нууцаар орон явж, Абинадайн үгсийг сургаж эхлэв—

2 Тийм ээ, ирэх зүйлүүдийн талаар, мөн түүнчлэн Христийн “хүч чадал, мөн тарчлал, мөн үхлээр, мөн түүний амилалт мөн тэнгэрт дээшлэн одоноор тохиосон үхэгсдийн амилуулалтын, мөн хүмүүсийн ⁶гэтэлгэлийн талаар буюу.

3 Мөн түүний үгийг анхааран сонсох болгонд тэрээр сургасан болой. Мөн тэрээр энэ нь хаанд мэдэгдэж болохгүйн тулд, тэдэнд нууцаар сургажээ. Мөн олон нь түүний үгсэд итгэв.

4 Мөнхүү улиран тохиох дор нэрээ тэндээс хүртсэн, мөн энэ нь нутгийн хязгаар бөгөөд цаг улирлаар зэрлэг амьтад хөлхөлдсөн Мормон гэж нэрлэгдсэн “нутагт түүнд итгэсэн болгон очиж байв.

5 Эдүгээ, Мормонд цэвэр устай булаг байв, мөн усны дэргэд өдрийн цагт хааны эрлээс тэрээр өөрийгөө далдлан нуудаг байсан багахан

төгөл байсан тул Алма тэнд очиж хоргодсон бөлгөө.

6 Мөнхүү улиран тохиох дор түүнд итгэсэн болгон түүний үгсийг сонсохоор тийш одож байв.

7 Мөнхүү улиран тохиох дор олон өдрийн дараа нилээд тооны хүмүүс Алмагийн үгсийг сонсохоор Мормоны нутагт цугларцгаав. Тийм ээ, түүний үгэнд итгэсэн бүгд түүнийг сонсохоор цугларсан байлаа. Мөн тэрээр тэдэнд “сургаж, мөн тэдэнд наманчлал, гэтэлгэл, мөн Их Эзэнд итгэх итгэлийг номлосон ажээ.

8 Мөнхүү улиран тохиох дор тэрээр тэдэнд хэлсэн нь: Болгоогтун, Мормоны Ус энэ байна (учир нь энэ нь тийн нэрлэгдсэн байв) мөн эдүгээ, та нар Бурханы “хороонд орж, мөн нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд мөн түүний хүмүүс гэж нэрлэгдэх ⁶хүсэлтэй байж, үүрэлцэхэд “бэлэн байв;

9 Тийм ээ, мөн гашуудах тэдний хамт гашуудахад; тийм ээ, тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулахад, мөн ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы “гэрчлэгч болж, үхэлд хүртлээ зогсоход бэлний учир, ⁶мөнх амьдралыг авч болохын тулд, Бурханаар гэтэлгэгдэж, мөн та нар

18 1a Мозая 23:9–10.

2a су Цагаатгах,
Цагаатгал.
б су Гэтэлгэх,
Гэтэлгэгдэх,

Гэтэлгэл.

4a Алма 5:3.

7a Алма 5:11–13.

8a С ба Г 20:37.

б су Есүс Христийн

Сүм.

в су Өрөвч сэтгэл.

9a су Номлолын

ажил; Гэрчлэх; Гэрч.

б су Мөнх амьдрал.

“анхны амилуулалтын тэдний дунд тоологдож болохын тулд буюу —

10 Эдүгээ би та нарт хэлнэ, хэрэв энэ нь та нарын зүрхний хүслэн байх аваас, тэр өөрийн Сүнсийг та нар дээр илүү элбэгээр юүлж болохын тулд, та нар түүнд үйлчилж мөн түүний зарлигуудыг дагана хэмээн “гэрээ байгуулснаа түүний өмнө гэрчилж, Их Эзэний нэрээр “баптисм хүртэхэд юу нь та нарт болохгүй байх билээ?

11 Мөн эдүгээ хүмүүс эдгээр үгийг дуулаад, тэд баярласнаас алгаа ташин, мөн ийн хашгирцгаав: Энэ бол бидний зүрхний хүслэн билээ.

12 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма, анхны хэдийн нэг байсан Хеламыг авч, мөн явж усан дотор зогсоод, мөн хашгирч, хэлсэн нь: Ай Их Эзэн, тэрээр энэ ажлыг зүрх сэтгэлийн ариунаар хийж болохын тулд өөрийн Сүнсийг та үйлчлэгчийнхээ дээр юүлээч.

13 Мөн эдгээр үгийг хэлэхэд, Их Эзэний “Сүнс түүн дээр байв, мөн тэр хэлэв: Хелам, Бүхнийг Чадагч Бурханаас “эрх мэдлийг хүлээн авсны учир, та зуурдын биеэ үхэн үхтэл түүнд үйлчлэхээр түүнтэй гэрээ байгуулж буйг гэрчлэн би танд “баптисм хүртээв;

мөн Их Эзэний Сүнс тан дээр юүлэгдэг; мөн тэрээр дэлхийн “үүслээс бэлтгэгдсэн Христийн “гэтэлгэлээр дамжуулан танд мөнх амьдралыг соёрхох болтугай.

14 Мөн Алма эдгээр үгсийг хэлсний дараа, Алма Хелам хоёул усанд “бүрхэгдэв; мөн тэд босож, мөн тэд Сүнсээр дүүргэгдсэн учир уснаас баясан гарч ирэв.

15 Мөн түүнчлэн, Алма өөр нэгийг авч, мөн хоёр дахь удаагаа усанд ороод, мөн түүнд эхнийхийн адилаар баптисм хүртээв, зөвхөн тэр өөрийгөө дахин усанд дүрсэнгүй.

16 Мөн энэ маягаар тэр Мормоны нутагт ирсэн болгонд баптисм хүртээв; мөн тэд тоогоор бараг хоёр зуун дөрвөн бодгаль байв; тийм ээ, мөн тэд Мормоны усанд “баптисм хүртэж, Бурханы “ач ивээлээр дүүргэгдсэн байв.

17 Мөн тэд тэр цагаас Бурханы “сүм буюу Христийн сүм гэж нэрлэгдэв. Мөнхүү улиран тохиох дор Бурханы хүч болон эрх мэдлээр баптисм хүртсэн хэн боловч түүний сүмд нэмэгдэж байв.

18 Мөнхүү улиран тохиох дор Алма, Бурханаас “эрх мэдэл хүлээн авсан тул, санваартнуудыг томилов; бүр тэдний

9в Мозая 15:21–26.
10а су Гэрээ.
б 2 Ниф. 31:17.
су БAPTисм,
БAPTисм хүртээх.
13а су Ариун Сүнс.
б ИТ 1:5.
су Санваартан.

в 3 Ниф. 11:23–26;
С ба Г 20:72–74.
г Мосе 4:2; 5:9.
д су Гэтэлгэх,
Гэтэлгэгдэх,
Гэтэлгэл.
14а су БAPTисм,
БAPTисм хүртээх—

Умбуулах баптисм.
16а Мозая 25:18.
б су Ач ивээл.
17а 3 Ниф. 26:21; 27:3–8.
су Есүс Христийн
Сүм.
18а су Санваартан.

тавь тутамд тэдэнд номлох, мөн тэдэнд Бурханы хаант улсад хамаатай зүйлүүдийн талаар ^бсургах нэг санваартныг тэрээр томилсон бөлгөө.

19 Мөн тэрээр тэд өөрийнх нь заасан, мөн ариун бошиглогчдын амаар яригдсанаас өөр юуг ч тэд заах ёсгүй хэмээн тэдэнд зарлиг буулгав.

20 Тийм ээ, бүр тэрээр тэд наманчлал түүнчлэн өөрийн хүмүүсийг гэтэлгэсэн Их Эзэнд итгэх итгэлээс өөр юуг ч “номлох ёсгүйг тэдэнд зарлиг болгов.

21 Мөн тэрээр тэдний өөр хооронд “зөрчилдөөн байх ёсгүй, харин нэг итгэл мөн нэг баптисмтай байж, зүрх сэтгэлээ эв нэгдэл хийгээд нэг нэгнийхээ зүг хандсан хайранд ^бнэгтгэн тэд ^внэг нүдээр урагш харах ёстой хэмээн тэдэнд зарлиг болгов.

22 Мөн ийн тэр тэдэнд номлохыг зарлиглав. Мөн тийн тэд Бурханы “хүүхдүүд болов.

23 Мөн тэд “хүндэтгэлийн өдрийг сахьж, мөн үүнийг ариун байлгах, мөн түүнчлэн өдөр бүр тэд Их Эзэн Бурхандаа талархлаа илэрхийлэх ёстойг тэрээр тэдэнд зарлиг болгов.

24 Мөн түүнчлэн тэрээр түүний томилсон санваартнууд өөрсдийн гараар “хөдөлмөр-

лож өөрсдийгөө гэжээх ёстой хэмээн тэдэнд зарлиг болгов.

25 Мөн тэд хүмүүст зааж, мөн Их Эзэн Бурханаа “шүтэхээр нэгдэн цугларах ёстой долоо хоног бүрийн нэг өдөр мөн түүнчлэн, өөрсдийн боломжоор ойр ойрхон чуулахаар тогтоогдов.

26 Мөн санваартнууд өөрсдийгөө тэтгэхийн тулд хүмүүс дээр түшиглэх биш; харин хөдөлмөрийнхөө хариуд Бурханы “ач ивээлийг авах байсан, тэд Бурханаас хүлээн авсан хүчтэйгээр мөн эрх мэдэлтэйгээр сургаж болохын тулд, Бурханы ^бмэдлэгтэй байж Сүнсэнд хүчтэй болж болохын тулд бөлгөө.

27 Мөн түүнчлэн сүмийн хүмүүс хөрөнгөнөөсөө, “хүн бүр өөрт байгаагийнхаа хэрээр өглөг хуваалцвал зохино; хэрэв түүнд илүү их хөрөнгө байваас илүү ихийг хуваалцах ёстой; мөн харин түүнд бага байвал, түүнээс багыг л шаардах ёстой; мөн юмгүй түүнд өгөгдөх ёстой хэмээн Алма зарлиг болгов.

28 Мөн тийн тэд өөрсдийн чөлөөт хүсэл, мөн Бурханд хандах сайн хүслийн учир, мөн гачигдах болсон тэдгээр санваартнуудад, тийм ээ, мөн гачигдалтай болгонд, нүцгэн бодгаль бүрд хөрөнгөнөөсөө өглөг болговол зохино.

18б су Заах, Багш.
20а С ба Г 15:6; 18:14–16.
21а З Ниф. 11:28–30.
су Уруу таталт.
б су Эв нэгдэл.
в Мат. 6:22;
С ба Г 88:67–68.

22а Мозая 5:5–7;
Моисе 6:64–68.
23а Мозая 13:16–19;
С ба Г 59:9–12.
24а Үйлс 20:33–35;
Мозая 27:3–5;
Алма 1:26.

25а су Шүтэн бишрэх.
26а су Ач ивээл.
б су Мэдлэг.
27а Үйлс 2:44–45;
4 Ниф. 1:3.

29 Мөн Бурханаар зарлиг-дуулсны учир, тэр үүнийг тэдэнд хэлэв; мөн нэг нэгэндээ тэдний гачигдал мөн тэдний хүслийн дагуу биеийн мөн сүнсний аль алиных нь “тусламжийг өгөн тэд Бурханы өмнө “шударгаар алхаж байв.

30 Мөн эдүгээ улиран тохиох дор энэ бүгд Мормон нутагт хийгдэв, тийм ээ, Мормоны Усны ойролцоо, Мормоны “Усны дэргэдэх төгөлд бөлгөө; тийм ээ, Мормоны нутаг, Мормоны Ус, Мормоны төгөл, тэнд Гэтэлгэгчийнхээ мэдлэгт ирсэн тэдний нүдэнд тэдгээр нь хичнээн үзэсгэлэнтэй билээ; тийм ээ, мөн тэд ямар их адислагдсан билээ, учир нь тэд үүрд түүнийг магтан дуулах болно.

31 Мөн эдгээр зүйлүүд, тэдгээр нь хаанд мэдэгдэж болохгүйн тулд нутгийн “хязгаарт болсон аж.

32 Гэвч болгоогтун, улиран тохиох дор хаан, хүмүүсийн дундах хөдөлгөөнийг олж мэдээд, тэднийг тандуулахаар зарц нараа илгээв. Тиймийн тул Их Эзэний үгийг дуулахаар нэгдэн цугларцгаасан тэр өдрөө тэд хаанд мэдэгдэв.

33 Мөн эдүгээ Алма түүнийг эсэргүүцүүлэхээр хүмүүсийг өдөөн хатгаж байна хэмээн хаан хэлэв; тиймийн тул тэрээр тэднийг устгахаар их цэргээ илгээв.

34 Мөнхүү улиран тохиох дор Алмад мөн Их Эзэний

хүмүүст хааны их цэрэг ирж буй талаар “мэдэгдэв; тиймийн тул тэд майхнуудаа мөн гэр бүлээ авч аглаг буйд тийш одов.

35 Мөн тэд тоогоороо дөрвөн зуун тавь орчим бодгаль байсан бөлгөө.

БҮЛЭГ 19

Гидеон Ноа хааныг хөнөөхөөр эрэлхийлэв—Леменчүүд уг нутагт халдав—Хаан Ноа галд шатаагдах үхлийг амсав—Лимхай алба төлөгч хаан болж захирав. Ойролцоогоор мээ 145–121 он.

Мөнхүү улиран тохиох дор хааны их цэрэг Их Эзэний хүмүүсийг үр ашиггүй хайсны эцэст эргэж ирэв.

2 Мөн эдүгээ болгоогтун, хааны цэргийн хүчин бага байж, цөөрсний учир болой, мөн үлдсэн хүмүүсийн дунд хагарал гарч эхлэв.

3 Мөн бага хэсэг нь хааны эсрэг сүрдүүлэх үг хэлж эхлээд, мөн тэдний дунд агуу зөрчилдөөн бий болж эхэллээ.

4 Мөн эдүгээ тэдний дунд Гидеон гэгч эр байв, мөн тэр хүчтэй мөн хааны дайсан байсан учир, тиймийн тул тэр илдээ сугалж, мөн хилгэнэсэндээ хааныг хөнөөнө хэмээн андгайлав.

5 Мөнхүү улиран тохиох дор тэр хаантай тулалдав; мөн тэрээр өөрийг нь хүчээр давамгайлах дөхсөнийг хаан

29a су Халамж.

б су Аллах, Бурхантай

хамт алхах.

30a Мозая 26:15.

31a Мозая 18:4.

34a Мозая 23:1.

хараад, тэрээр зугтаж мөн ариун сүмийн дэргэдэх “цамхаг өөд гүйж гарав.

6 Мөн Гидеон түүний араас мөрдөж мөн хааныг хөнөөхөөр цамхагт гарахаар эхэв, мөн хаан Шимлон нутгийн зүг хараа бэлчээсэнд, мөн болгоогтун, леменчүүдийн их цэрэг нутгийн хил даван ирсэн байлаа.

7 Мөн эдүгээ хаан сэтгэлийн тарчлалдаа бахардан хашгирч, өгүүлсэн нь: Гидеон, намайг хэлтрүүлээч, учир нь леменчүүд бидний дээр байна, мөн тэд биднийг устгах болно; тийм ээ, тэд хүмүүсийг минь устгах болно.

8 Мөн эдүгээ хаан амиа бодсон шигээ хүмүүсийнхээ талаар тэгж их шаналсангүй; гэсэн хэдий ч, Гидеон түүний амийг хэлтрүүлэв.

9 Мөн тэд леменчүүдийн өмнө зугтах ёстой хэмээн хаан хүмүүст зарлиглаж, мөн тэр өөрөө тэдний өмнө явав, мөн тэд эмэгтэйчүүд мөн хүүхдүүдтэйгээ хамт аглаг буйд тийш зугтав.

10 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд тэднийг мөрдсөн аж, мөн тэднийг гүйцэж, мөн тэднийг хөнөөж эхлэв.

11 Эдүгээ улиран тохиох дор хаан бүх эрсийг эхнэр, хүүхдүүдээ орхиж, мөн леменчүүдийн өмнө зугтахыг тэдэнд зарлиг болгов.

12 Эдүгээ тэднийг орхихгүй харин үлдэж мөн тэдэнтэй хамт мөхөх нь дээр хэмээсэн

нь олон байв. Мөн үлдсэн нь эхнэр хүүхдүүдээ орхиж мөн зугтав.

13 Мөнхүү улиран тохиох дор эхнэр мөн хүүхдүүдийнхээ хамт хоцорсон тэд үзэсгэлэнт охидоо леменчүүдийн өмнө очиж зогсоогоод мөн өөрсдийг нь алахгүй байхыг гуйхаар болгов.

14 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд тэднийг өрөвдөв, учир нь тэд эмэгтэйчүүдийнх нь гоо үзэсгэлэнд сэтгэл тагдсан бөлгөө.

15 Тиймийн тул леменчүүд тэдний амийг хэлтрүүлж, мөн тэднийг боолчлолд оруулж мөн Нифайн нутагт буцааж авчрав, тэд хаан Ноаг леменчүүдийн гарт өгч, мөн өөрсдийн хөрөнгийг, бүр тэд эзэмшсэн бүгдийнхээ тэн хагасыг, алтныхаа мөн мөнгөнийхөө хагасыг, мөн бүх үнэт зүйлсийнхээ хагасыг өгөх нөхцөл дор тэд уг нутгийг эзэмшиж болохыг тэдэнд зөвшөөрөв, мөн тийн тэд леменчүүдийн хаанд жилээс жилд алба гувчуур төлөх ёстой байв.

16 Мөн эдүгээ боолчлолд орсон тэдний дунд хааны хөвгүүдийн нэг болох нэр нь “Лимхай гэгч нэгэн байв.

17 Мөн эдүгээ Лимхай эцгээ бүү устгагдаасай хэмээх хүсэлтэй байв; гэсэн хэдий ч, Лимхай эцгийнхээ алдсуудыг үл мэдэгч биш байв, тэр өөрөө шударга хүн байсных бөлгөө.

18 Мөнхүү улиран тохиох дор Гидеон хааныг мөн түүнтэй хамт буй тэднийг хайлгахаар хүмүүсийг аглаг буйд тийш нууцаар илгээв. Мөнхүү улиран тохиох дор тэд аглаг буйдад хүмүүстэй, хаан мөн санваартнуудаас бусад бүгдтэй нь уулзав.

19 Эдүгээ тэд Нифайн нутагт эргэж очно, мөн хэрэв тэдний эхнэр мөн хүүхдүүд нь мөн түүнчлэн тэдэнтэй үлдсэн тэд алагдсан бол тэд өшөөгөө авахаар эрэлхийлнэ, мөн түүнчлэн тэдэнтэй хамт мөхөх болно хэмээн тэд зүрх сэтгэлдээ андгайлсан байв.

20 Мөн хаан тэднийг буцах ёсгүй хэмээн тэдэнд зарлиг болов; мөн тэд хаанд уурлаж, мөн түүнийг зовох болгов, бүр “галд шатаагдах үхлийг хүртэл буюу.

21 Мөн тэд санваартнуудыг ч түүнчлэн барьж мөн тэднийг үхэлд хүргэхээр завдаж байв, мөн тэд тэднээс зугтан одов.

22 Мөнхүү улиран тохиох дор тэд Нифайн нутаг тийш буцахаар зэхэж, мөн тэд Гидеоны эрчүүдтэй уулзав. Мөн Гидеоны эрчүүд тэдэнд, тэдний эхнэр хүүхдүүдэд тохиолдсон бүгдийг; мөн тэд леменчүүдэд өөрсдийн бүх эзэмшлийн тэн хагасыг алба гувчуур болгон төлж байвал уг нутгийг эзэмшиж болно хэмээн леменчүүд тэдэнд зөвшөөрснийг ярьсан буюу.

23 Мөн уг хүмүүс Гидеоны эрчүүдэд тэд хааныг алснаа, мөн түүний санваартнууд тэднээс аглаг буйдын илүү алслагдсан хэсэг уруу зугтсаныг хэлэв.

24 Мөнхүү улиран тохиох дор тэд уг ёслолыг төгсгөсний дараа тэд Нифайн нутагт байсан эргэж ирэв, тэдний эхнэр мөн хүүхдүүд алагдсангүйн учир бөлгөө; мөн тэд хааныг яаснаа Гидеонд хэлэв.

25 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн хаан өөрийнх нь хүмүүс тэднийг алахгүй хэмээн тэдэнд “ам өгөв.

26 Мөн түүнчлэн Лимхай, хааны хүү байсан учир, хаант улсыг удирдахаар “хүмүүсээр тохоогдсон учир, леменчүүдийн хаанд өөрийнх нь хүмүүс түүнд алба, бүр бүх эзэмшлийнхээ тэн хагасыг төлнө хэмээн ам өгөв.

27 Мөнхүү улиран тохиох дор Лимхай хаант улсыг байгуулж мөн өөрийн хүмүүсийн дунд энх амгаланг тогтоож эхлэв.

28 Мөн леменчүүдийн хаан тэрээр Лимхайн хүмүүсийг нутагт нь байлгаж, тэднийг аглаг буйд тийш одуулахгүйн тулд нутгийн эргэн тойронд харуулууд гаргав; мөн тэрээр харуулуудаа нифайчуудаас хүлээн авсан алба гувчуураар тэтгэж байв.

29 Мөн эдүгээ леменчүүд тэднийг гоочилсонгүй бас устгахыг эрэлхийлсэн нь үгүй

тул хаан Лимхай хаант улсдаа хоёр жилийн турш үргэлжийн энх амгаланг эдлэв.

БҮЛЭГ 20

Лемен үндэсний зарим охид Ноагийн санваартнуудад хулгайлагдав—Леменчүүд Лимхай болон түүний хүмүүстэй дайтав—Леменчүүдийн дайчид ухран туугдаж мөн тайвшруулагдав. Ойролцоогоор мээ 145–123 он.

Эдүгээ Шимлонд леменчүүдийн охид хамтдаа дуулж, бүжиглэж, мөн цэнгэцгээхээр цуглардаг нэгэн газар байлаа.

2 Мөнхүү улиран тохиох дор нэгэн өдөр тэднээс цөөн хэд нь дуулж, бүжиглэхээр цугларцгаасан бөлгөө.

3 Мөн эдүгээ хаан Ноагийн санваартнууд, Нифай хотод эргэж очихоос ичиж, тийм ээ, мөн түүнчлэн хүмүүс тэднийг алах болов уу гэхээс айж, тиймийн тул тэд эхнэр, хүүхдүүддээ буцаж зүрхэлсэнгүй.

4 Мөн аглаг буйдад үлдсэн учир, мөн леменчүүдийн охидыг олж мэдсэний учир, тэд нуугдаж хэвтэн мөн тэднийг ажиглав;

5 Мөн цөөн хэд нь бүжиглэхээр цугларсан үед, тэд нуугдсан газруудаасаа гарч ирээд мөн тэднийг барьж, мөн тэднийг аглаг буйд тийш авч одов; тийм ээ, леменчүүдийн охидоос хорин дөрвийг нь тэд аглаг буйд тийш авч одсон буюу.

6 Мөнхүү улиран тохиох

дор леменчүүд тэдний охид алга болсныг олж мэдээд, тэд Лимхайн хүмүүст уурлав, учир нь энэ нь Лимхайн хүмүүс байсан гэж тэд боджээ.

7 Тиймийн тул тэд их цэргээ илгээв; тийм ээ, бүр хаан өөрөө хүмүүсийнхээ өмнө явав; мөн тэд Лимхайн хүмүүсийг устгахаар Нифайн нутаг өөд одов.

8 Мөн эдүгээ Лимхай тэднийг цамхгаас олж хараад, бүр дайны бүрэн бэлтгэлтэй байгааг тэр олж мэдэв; тиймийн тул тэр хүмүүсээ цуглуулж, мөн талбайд мөн ойд хэвтэн тэднийг хүлээв.

9 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийг өгсөж ирэх үед, Лимхайн хүмүүс хүлээж байсан газраасаа гарч тэдний зүг дайран, мөн тэднийг алж эхлэв.

10 Мөнхүү улиран тохиох дор тулалдаан үлэмж ширүүн болов, учир нь тэд идшээ харамласан арслангууд лугаа адил тулалдсан бөлгөө.

11 Мөнхүү улиран тохиох дор Лимхайн хүмүүс леменчүүдийг өмнөө туун ухрааж эхлэв; гэсэн хэдий ч тэд леменчүүдийн хагаст нь хүрэхгүй цөөн байв. Гэвч тэд амьдралынхаа төлөө мөн эхнэр хүүхдүүдийнхээ төлөө “тулалдсан ажээ; тиймийн тул тэд улайрч мөн луунууд лугаа адил тулалдацгаав.

12 Мөнхүү улиран тохиох дор тэд леменчүүдийн хааныг үхэгсдийн дунд олов; гэвч тэр

үхээгүй, шархдаж мөн газар орхигдсон байв, түүний хүмүүсийн зугталт тийм хурдан байсан ажгуу.

13 Мөн тэд түүнийг барьж мөн шархыг нь боогоод, мөн Лимхайн өмнө түүнийг авчирч, мөн хэлэв: Болгоогтун, леменчүүдийн хаан энд байна; тэрээр шарх олсон тул үхэгсдийн дунд унасан байв, мөн тэд түүнийг орхин оджээ; мөн болгоогтун, бид түүнийг таны өмнө авчирлаа; мөн эдүгээ түүнийг хөнөөцгөөе хэмээв.

14 Гэвч Лимхай тэдэнд хэлэв: Та нар түүнийг хөнөөхгүй, харин би түүнийг харж болохын тулд түүнийг нааш авчрагтун. Мөн тэд түүнийг авчрав. Мөн Лимхай түүнд хэлэв: Миний хүмүүсийн эсрэг дайтахаар ирэх ямар шалтгаан танд байдаг билээ? Болгоогтун, миний хүмүүс миний танд “ам өгснийг зөрчөөгүй билээ; тиймийн тул, та нар яагаад миний хүмүүст амласнаа зөрчих болов?

15 Мөн эдүгээ хаан хэлэв: Би амлалтаа зөрчсөн, учир нь танай хүмүүс миний хүмүүсийн охидыг барьж одсон буюу; тиймийн тул, би уурандаа өөрийн хүмүүсийг танай хүмүүсийн эсрэг дайтахаар ирэх болгосон билээ.

16 Мөн эдүгээ Лимхай энэ явдлын талаар юу ч сонсоогүй байв; тиймийн тул тэр хэлэв: Би өөрийн хүмүүсийн дунд эрье, мөн ийм зүйлийг

үйлдсэн хэн боловч мөхөх болно. Тиймийн тул тэрээр хүмүүсийнхээ дунд нэгжлэг хийлгэв.

17 Эдүгээ “Гидеон эдгээр зүйлийг сонсоод, тэрээр хааны ахмад байсан тул тэрээр дөхөж очин мөн хаанд: Би танаас хүлцэхийг гуйя, мөн энэ хүмүүсийг бүү нэгж, мөн энэ зүйлийг тэдэн дээр бүү тохооч хэмээв.

18 Учир нь та энэ хүмүүсийг устгахаар эрэлхийлсэн эцгийнхээ санваартнуудыг санахгүй байна гэж үү? Мөн тэд аглаг буйдад байгаа бус уу? Мөн леменчүүдийн охидыг хулгайлсан нь тэд бус уу?

19 Мөн эдүгээ, болгоогтун, мөн эдгээр зүйлийг хаанд хэлэгтүн, тэднийг бидний тухайд тайвшруулж болохын тулд тэрээр өөрийн хүмүүст хэлж болохын тулд буюу; учир нь болгоогтун тэд аль хэдийн бидний эсрэг ирэхээр бэлтгэж байна; мөн болгоогтун түүнчлэн бид цөөн билээ.

20 Мөн болгоогтун, тэд олон тооны дайчидтайгаа ирэх болно; мөн хаан тэднийг бидний тухайд тайвшруулахаас бусдаар бол бид мөхөх ёстой боллоо.

21 Учир нь бидний эсрэг түүний бошиглосон — мөн энэ бүгд бид Их Эзэний үгсийг анхааран сонсохгүй мөн алдсуудаасаа салахгүй байгаагийн учир, мөнөөх Абинадайн үгс “биелэгдсэн бус уу?

22 Мөн эдүгээ хааныг тайвш-

руулцгаая, мөн бид түүнд өгсөн амлалтаа биелүүлье; учир нь амиа алдсанаас боолчлолд байх нь илүү дээр бөлгөө; тиймийн тул, ийм их цус урсгахаа зогсооцгооё.

23 Мөн эдүгээ эцгийнхээ мөн аглаг буйдад зугтсан “санваартнуудынхаа талаар бүх зүйлийг Лимхай хаанд хэлж, мөн охидыг нь авч одсон хэмээн тэднийг буруутгав.

24 Мөнхүү улиран тохиох дор хаан түүний хүмүүсийн тухайд тайвшрав; мөн тэрээр тэдэнд: Бүгдээрээ зэвсэггүйгээр миний хүмүүстэй уулзахаар явцгаая; мөн би та нарт миний хүмүүс танай хүмүүсийг алахгүй хэмээн ам өгч тангараглая гэв.

25 Мөнхүү улиран тохиох дор тэд хааныг дагаж, мөн зэвсэггүйгээр леменчүүдтэй уулзахаар явлаа. Мөнхүү улиран тохиох дор тэд леменчүүдтэй уулзав; мөн леменчүүдийн хаан тэдний өмнө өөрөө бөхийж, мөн Лимхайн хүмүүсийн өмнөөс гуйв.

26 Мөн леменчүүд Лимхайн хүмүүсийг зэвсэггүй байгааг хараад тэднийг өрөвдөж мөн тэдний тухайд “тайвшрав, мөн хаантайгаа хамт нутгийнхаа зүг амар амгалан буцацгаав.

БҮЛЭГ 21

Лимхайн хүмүүс леменчүүдээр цохигдож мөн ялагдав— Лимхайн хүмүүс Аммонтой уулзаж

мөн хөрвүүлэгдэв— Тэд жардчуудын хорин дөрвөн ялтсын тухай Аммонд хэлэв. Ойролцоогоор мээ 122–121 он.

Мөнхүү улиран тохиох дор Лимхай мөн түүний хүмүүс Нифайн хотод эргэж ирээд, мөн нутагтаа дахин амар амгалан амьдарч эхлэв.

2 Мөнхүү улиран тохиох дор олон хоногийн дараа леменчүүд нифайчуудын эсрэг уурандаа өдөөгдөж эхлээд мөн тэд эргэн тойрны нутгийн хил орчмоор дахин ирэх болов.

3 Эдүгээ тэднийг хөнөөж тэд зүрхэлсэнгүй, Лимхайд өгсөн тэдний хааны амлалтын учир бөлгөө; гэвч тэд “хацар дээр нь тэднийг алгадаж, мөн тэдний дээр эрх дархаа үзүүлэв; мөн тэдний нуруунд хүнд ачаануудыг тавьж мөн тэднийг хэлгүй илжиг лугаа адил тууж эхлэв—

4 Тийм ээ, энэ бүгд Их Эзэний үг биелэгдэж болохын тулд хийгдсэн ажгуу.

5 Мөн эдүгээ нифайчуудын зүдгүүрүүд агуу байж, мөн тэдний гараас тэд өөрсдийгөө чөлөөлж чадах зам үгүй байв, учир нь леменчүүд тэдний тал бүрээс бүсэлсэн ажээ.

6 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс өөрсдийн зүдгүүрүүдийн учир хаанд хандан бувтналдаж эхлэв; мөн тэдний эсрэг тулалдахаар явах хүсэл тэдэнд байх болов. Мөн тэд өөрсдийн гомдоллох

үгсээрээ хааныг ихэд зовоож байв; тиймийн тул тэрээр тэд хүслийнхээ дагуу үйлдэхийг тэдэнд зөвшөөрөв.

7 Мөн тэд дахин өөрсдөө цугларцгааж, мөн хуяг дуулгаа өмсөж, мөн леменчүүдийн эсрэг тэднийг нутгаасаа хөөн гаргахаар явцгаалаа.

8 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд тэднийг дийлж, мөн тэднийг ухраан, мөн тэдний олныг нь хөнөөв.

9 Мөн эдүгээ Лимхайн хүмүүсийн дунд агуу “гашуудал мөн гаслан байв, бэлэвсэн эхнэр нөхрийнхөө төлөө гашуудан, хүү болон охин нь эцгийнхээ төлөө, мөн ах дүүс ах дүүсийнхээ төлөө гашуудаж байв.

10 Эдүгээ уг нутагт тун олон бэлэвсэн эхнэр байв, мөн тэд өдрөөс өдөрт ихээр орь дуу тавьж байв, учир нь леменчүүдээс айх их айдас тэдний дээр ирсэн бөлгөө.

11 Мөнхүү улиран тохиох дор тэдний үргэлжийн уйлаан Лимхайн хүмүүсийн үлдсэнийг леменчүүдийн эсрэг уурлуулахад өдөөн хатгав; мөн тэд дахин тулалдахаар явав, гэвч тэд дахин ухраагдаж, их хохирол хүлээв.

12 Тийм ээ, тэд бүр гурав дахь удаагаа дахин явж, мөн урьдын адил хохирол амсав; мөн алагдаагүй тэд Нифайн хотод дахин эргэж ирэв.

13 Мөн тэд өөрсдийгөө боолчлолын буулганд харъяа-

луулан, өөрсдийгөө цохигдохыг, мөн нааш цааш туугдахыг, мөн дайснуудынхаа хүслийн дагуу хүнд ачаа үүрэхийг хүлцэн, тэд өөрсдийгөө бүр тоос шороотой адилтган даруусгав.

14 Мөн тэд өөрсдийгөө бүр төлөв байдлын гүнд хүргэн “даруусгав; мөн тэд Бурханаас хүчтэйгээр гуйв; тийм ээ, бүр бүх өдрийн турш тэрбээр өөрсдийг нь зүдгүүрүүдээс чөлөөлөөсэй хэмээн Бурхандаа залбиран гуйсан бөлгөө.

15 Мөн эдүгээ Их Эзэн алдсуудых нь учир тэдний гуйлтыг “сонсохдоо удаан байв; гэсэн хэдий ч Их Эзэн тэдний гуйлтуудыг сонсож, мөн тэдний ачааг хөнгөлж эхлэхийн тулд леменчүүдийн зүрх сэтгэлийг уярааж эхлэв; гэвч Их Эзэн тэднийг боолчлолоос чөлөөлөх нь зүйд нийцнэ хэмээсэнгүй болой.

16 Мөнхүү улиран тохиох дор тэд нутагтаа бага багаар дэгжиж эхлэв, мөн тэд өлсгөлөнгөөр зовохгүйн тулд, илүү ихээр үр тариаг, мөн бог мал, мөн бод малыг өсгөж эхлэв.

17 Эдүгээ эмэгтэйчүүдийн тоо нь маш их, эрчүүдээс олон байв; тиймийн тул хаан Лимхай эр хүн болгон “бэлэвсэн эхнэрүүд мөн тэдний хүүхдүүдийг, тэднийг өлсгөлөнгөөр үхүүлэхгүй байж болохын тулд ^бтэтгэхийг зарлиг болгов; мөн тэдний

9а Мозая 12:4.
14а Мозая 29:20.
су Даруу, Даруу

байдал.
15а Сур. үгс 15:29;
Мозая 11:23–25;

С ба Г 101:7–9.
17а су Бэлэвсэн.
б Мозая 4:16, 26.

үрэгдэгсдийн олны учир тэд үүнийг хийсэн ажээ.

18 Эдүгээ Лимхайн хүмүүс аль болох хэсэг хэсгээрээ хамтдаа байж, мөн тариа будаагаа мөн мал сүргээ хамгаалав;

19 Мөн хаан өөрөө харуулуудтайгаа бус аваас хотын хэрэмнээс гадагш үл гарна, тэрээр ямар нэгэн байдлаар леменчүүдийн гарт орох бий хэмээн айсны учир бөлгөө.

20 Мөн тэрээр леменчүүдийн “охидыг хулгайлж, мөн өөрсдийн дээр тийм агуу устгалыг ирүүлсэн, аглаг буйдад зугтсан мөнөөх санваартнуудыг барьж болохын тулд нутгийнхаа эргэн тойрныг өөрийн хүмүүсээр тэр тандуулав.

21 Учир нь тэд шийтгэж болохын тулд тэднийг баривчлах хүсэлтэй байв; учир нь Нифайн нутагт шөнөөр тэд ирж, мөн тэдний ургац бас үнэт зүйлээс нь олныг авч одсон ажээ; тиймийн тул тэд нуугдаж хэвтээд тэднийг хүлээв.

22 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд болон Лимхайн хүмүүсийн дунд, бүр “Аммон болон түүний ах дүүсийг уг нутагт ирсэн тэр цагийг хүртэл дахин зөрчил гарсангүй.

23 Мөн хаан харуултайгаа хамт хотын хаалганы гадна байхдаа Аммон болон түүний ах дүүсийг олж харжээ; мөн тэднийг Ноагийн санваартнууд хэмээн бодож, тиймийн тул тэрээр тэднийг баривч-

луулж, мөн хүлүүлж, мөн “шоронд хориулсан ажгуу. Мөн хэрэв тэд Ноагийн санваартнууд байсан аваас тэр тэднийг үхэлд хүргүүлэх байсан буйза.

24 Гэвч тэрбээр тэднийг биш гэдгийг, харин тэд Зарахемлагийн нутгаас ирсэн өөрийнх нь ах дүүс болохыг олж мэдээд, тэр үлэмж агуу баяраар дүүрэв.

25 Эдүгээ хаан Лимхай Аммоныг ирэхээс өмнө “цөөн тооны эрчүүдийг Зарахемлагийн нутгийг ^бхайлгахаар илгээсэн байв; гэвч тэд үүнийг олж чадсангүй, мөн тэд аглаг буйдад төөрсөн бөлгөө.

26 Гэсэн хэдий ч, тэд хүмүүс суурьшсан байсан тэр нутгийг олжээ; тийм ээ, өгөр “ясаар хучигдсан тэр нутгийг; тийм ээ, хүмүүс суурьшсан байсан мөн устгагдсан тэрхүү нутгийг буюу; мөн тэд, энэ нь Зарахемлагийн нутаг хэмээн бодож, Нифайн нутагт эргэж ирэн, Аммоныг ирэхээс олон бус өдрийн өмнө нутгийн хилд хүрч ирсэн бөлгөө.

27 Мөн тэд өөрсөдтэйгөө нэгэн цэдэг авчирчээ, бүр ясыг нь олсон тэдгээр хүмүүсийн цэдгийг тэд олсон байв; мөн энэ нь хүдрийн ялтсууд дээр сийлбэрлэгдсэн байв.

28 Мөн эдүгээ Аммоны амнаас хаан Мозаяд Бурханаас өгөгдсөн ийм сийлбэрүүдийг хөрвүүлж чадах “бэлэг буйг мэдээд Лимхай дахин баяс-

20a Мозая 20:5.

22a Мозая 7:6–13.

23a Хил. 5:21.

25a Мозая 8:7.

б Мозая 7:14.

26a Мозая 8:8.

28a Омнаи 1:20–22;

Мозая 28:11–16.

лаар дүүрэв; тийм ээ, мөн түүнчлэн Аммон ч баясав.

29 Гэвч тэдний ах дүүсээс ийм олон нь алагдсаны учир Аммон болон түүний ах дүүс харамслаар дүүрэн байлаа;

30 Мөн түүнчлэн хаан Ноа болон түүний санваартнууд хүмүүсийг Бурханы эсрэг ийм олон нүгэл мөн алдсуудыг үйлдэхэд хүргэсэн учир; мөн тэд түүнчлэн Абинадайн “үхлийн төлөө гашуудав; мөн түүнчлэн Бурханы хүч болон чадлаар, мөн Абинадайгаар яригдсан үгсэд итгэсэн итгэлээр Бурханы сүмийг байгуулсан Алма мөн түүнтэй хамт одсон хүмүүс ^бдайжин одсоны төлөө болой.

31 Тийм ээ, тэднийг дайжсаны төлөө тэд гашуудаж байлаа, учир нь тэд хааш зугтсаныг тэд мэдэхгүй байв. Эдүгээ тэд баяртайгаар тэдэнтэй нэгдэх байсан сан, учир нь тэд өөрсдөө түүнд үйлчилж мөн түүний зарлигуудыг дагахаар Бурхантай гэрээнд орсон болой.

32 Мөн эдүгээ Аммоныг ирснээс хойш түүнчлэн хаан Лимхай, мөн түүнчлэн түүний хүмүүсийн олон нь түүнд үйлчилж мөн түүний зарлигуудыг дагахаар Бурхантай гэрээнд орсон байв.

33 Мөнхүү улиран тохиох дор хаан Лимхай хийгээд түүний хүмүүсийн олон нь баптисм хүртэх хүсэлтэй байв; гэвч уг нутагт Бурханаас “эрх мэдэлтэй нь нэг ч байсангүй. Мөн

Аммон өөрийгөө зохист бус үйлчлэгч хэмээн бодож, энэ зүйлийг хийхээс татгалзав.

34 Тиймийн тул, тэд Их Эзний Сүнсийг хүлээж байсны учир тэр цагт өөрсдийгөө сүм болгон зохион байгуулсангүй. Эдүгээ тэд бүр аглаг буйдад зугтсан Алма болон түүний ах дүүс лугаа адил болох хүсэлтэй байв.

35 Бүх зүрх сэтгэлээрээ тэд Бурханд үйлчлэхэд бэлнийхээ баталгаа хийгээд гэрч болгон тэд баптисм хүртэх хүсэлтэй байв; гэсэн хэдий ч тэд уг цагийг хойш тавив; мөн тэдний баптисмын шастир хожим “өгөгдөх болно.

36 Мөн эдүгээ Аммоны мөн түүний хүмүүсийн, мөн хаан Лимхай болон түүний хүмүүсийн бүхий л бодолхийлэл нь өөрсдийгөө леменчүүдийн гараас мөн боолчлолоос чөлөөлөхөд зориулагдсан бөлгөө.

БҮЛЭГ 22

Хүмүүсийг леменчүүдийн боолчлолоос оргуулах төлөвлөгөө хийгдэв — Леменчүүд согтоогдов — Хүмүүс оргож, Зарахемлад эргэж ирээд, мөн хаан Мозаягийн харъяат болов. Ойролцоогоор мээ 121–120 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Аммон болон хаан Лимхай тэд өөрсдийгөө хэрхэн боолчлолоос чөлөөлөх талаар хүмүүстэйгээ зөвлөлдөж эхлэв; мөн тэд бүр бүх

30a Мозая 17:12–20.
б Мозая 18:34–35.

33a су Эрх мэдэл.
35a Мозая 25:17–18.

хүмүүсийг цуглахаар болгов; мөн тэд үүнийг уг хэргийн талаар хүмүүсийн саналыг мэдэж болохын тулд үйлдэв.

2 Мөнхүү улиран тохиох дор тэд эмэгтэйчүүд мөн хүүхдүүдээ, мөн бог мөн бод малаа, мөн майхнуудаа авч мөн аглаг буйд тийш одохоос өөр, өөрсдийгөө боолчлолоос чөлөөлөх ямар ч зам тэдэнд олдсонгүй; учир нь леменчүүд маш олон тоотой байсан тул, илдээр өөрсдийгөө боолчлолоос чөлөөлнө хэмээн бодож тэдэнтэй тэмцэлдэх нь Лимхайн хүмүүсийн хувьд боломжгүй байв.

3 Эдүгээ улиран тохиох дор Гидеон дөхөж очин хааны өмнө зогсоод, мөн түүнд хэлэв: Эдүгээ, Ай хаантан, та эдүгээг хүртэл бид өөрсдийн ах дүүс, леменчүүдтэй тэмцэлдэж байхад миний үгсийг олон удаа сонссон билээ.

4 Мөн эдүгээ Ай хаантан, хэрэв та намайг ашиггүй зарц хэмээн эс тооцсон, өөрөөр хэлбэл эдүгээг хүртэл миний үгсийг ямар нэгэн хэмжээгээр сонсож, мөн тэдгээр нь танд тус болсон аваас, тэрчлэн энэ үед таныг миний үгсийг анхааран сонсоосой хэмээн хүснэ би, мөн би таны зарц байж мөн энэ хүмүүсийг боолчлолоос чөлөөлөх болно.

5 Мөн хаан түүнд тэрээр ярьж болно хэмээн зөвшөөрөв. Мөн Гидеон түүнд ярьсан нь:

6 Хотын ар талд буй арын ханыг, арын гарцыг болгоогтун. Леменчүүд, өөрөөр хэл-

бэл леменчүүдийн харуулууд, шөнөөр согтуу байдаг; тиймийн тул тэд шөнөөр тэдгээрийг аглаг буйд тийш тууж болохын тулд бог мөн бод малаа цуглуулцгаа хэмээн энэ бүх хүмүүсийн дунд зар тараая.

7 Мөн би таны зарлигийн дагуу явж мөн леменчүүдэд дарсны сүүлчийн албыг төлье, мөн тэд согтох болно; мөн тэднийг согтоод мөн унтаж байх зуур тэдний байрлалын зүүн гар талын нууц гарцаар бид гарах болно.

8 Тийн бид эмэгтэйчүүд мөн хүүхдүүдтэйгээ, бог мөн бод малтайгаа аглаг буйд тийш дайжих болно; мөн бид Шиломын нутгийг тойрон явах болно.

9 Мөнхүү улиран тохиох дор хаан Гидеоны үгсийг анхааран сонсов.

10 Мөн хаан Лимхай өөрийн хүмүүсийг мал сүргээ цуглуулах болгов; мөн тэр леменчүүдэд алба болгон дарс илгээв; мөн түүнчлэн тэрээр тэдэнд бэлэг болгон илүү дарс илгээв; мөн тэд хаан Лимхайн тэдэнд илгээсэн дарснаас ханатлаа уусан болой.

11 Мөнхүү улиран тохиох дор хаан Лимхайн хүмүүс шөнөөр бог мөн бод малтайгаа аглаг буйдад одож, мөн тэд Шилом нутгийг тойрон аглаг буйд тийш явж, мөн Аммон болон түүний ах дүүсээр удирдагдан Зарахемла нутгийн зүг чиглэв.

12 Мөн тэд тээж чадахын хэрээр бүх алт, мөн мөнгө, мөн

үнэт зүйлүүдээ мөн түүнчлэн хүнсээ аглаг буйд тийш авч явсан байв; мөн тэд аянаа үргэлжлүүлэв.

13 Мөн аглаг буйдад олон өдөр байсны дараа тэд Зарахемла нутагт хүрэлцэн ирэв, мөн Мозаягийн хүмүүстэй нэгдэж, мөн түүний харъяатууд болов.

14 Мөнхүү улиран тохиох дор Мозая тэднийг баяртайгаар угтав; мөн түүнчлэн тэрээр тэдний “цэдгүүдийг, мөн түүнчлэн Лимхайн хүмүүсийн олсон тэрхүү “цэдгүүдийг хүлээж авав.

15 Мөн эдүгээ улиран тохиох дор леменчүүд Лимхайн хүмүүс шөнөөр уг нутгаас дайжин одсоныг олж мэдээд, тэднийг мөрдөн хөөлгөхөөр аглаг буйд тийш их цэрэг илгээв;

16 Мөн тэд хоёр өдөр тэднийг мөрдсөний эцэст, мөрийг нь дагаж чадахаа больж; тиймийн тул тэд аглаг буйдад төөрчээ.

Хаан Ноагийн хүмүүсээр аглаг буйд тийш туугдсан Их Эзэний тэр хүмүүсийн мөн Алмагийн шастир оршвой.

23 болон 24 дүгээр
бүлэгт агуулагдав.

БҮЛЭГ 23

Алма хаан байхаас татгалзав
—Тэрээр дээд санваартан болж

үйлчлэв—Их Эзэн өөрийн хүмүүсийг зэмлэж, мөн леменчүүд Хилам нутгийг эзлэв—Хаан Ноагийн ёс бус санваартнуудын удирдагч Амюлон, Лемений хаант засагт харъяалагдан захирах болов. Ойролцоогоор мээ 145–121 он.

Эдүгээ Алма, хаан Ноагийн их цэрэг тэдэн дээр ирэхийг Их Эзэнээс урьдаас сэрэмжлүүлэгдэж, мөн тэрээр өөрийн хүмүүст үүнийг мэдүүлсэн тул, тиймийн тул тэд мал сүргээ цуглуулж, мөн үр тарианаасаа аваад, мөн хаан Ноагийн их цэргээс өмнө аглаг буйд тийш дайжив.

2 Мөн хаан Ноагийн хүмүүс тэднийг устгахаар тэднийг гүйцэж чадахгүйн тулд Их Эзэн тэднийг хүчирхэгжүүлсэн болой.

3 Мөн тэд найм хоногийн турш аглаг буйдаар зугтав.

4 Мөн тэд нэгэн нутагт тийм ээ, бүр маш үзэсгэлэнтэй мөн тааламжтай нутагт, цэвэр уст нутагт иржээ.

5 Мөн тэд майхнуудаа босгож, мөн газар боловсруулж эхлэв, мөн барилгууд барьж эхлэв; тийм ээ, тэд ажилсаг байж, мөн үлэмж шаргуу хөдөлмөрлөсөн болой.

6 Мөн хүмүүс Алмаг өөрсдийн хаан байгаасай хэмээн хүсч байв, учир нь тэр өөрийн хүмүүсээр хайрлагдсан бөлгөө.

7 Гэвч тэрээр тэдэнд хэлэв: Болгоогтун, бидэнд хаан байх нь зохистой бус юм; учир

нь Их Эзэн ийн хэлдэг: Та нар нэгэн биеийг нөгөөгөөс “илүүд үзэх ёсгүй, өөрөөр хэлбэл хэн нэг нь өөрийгөө бусдаас дээгүүрт бодох ёсгүй; тиймийн тул би та нарт хэлье, та нар хаантай байх нь зохистой бус.

8 Гэсэн хэдий ч, хэрэв та нар шударга эрчүүдийг хаан болгож чадах үргэлжийн боломжтой байсан бол хаантай байх нь та нарт сайн юм.

9 Гэвч хаан Ноагийн мөн түүний санваартнуудын “алдсыг санагтун; мөн би өөрөө ч урхинд ^борсон байж, мөн намайг зовлонт наманчлалд хүргэсэн, Их Эзэний мэлмийд жигшүүрт болох тэр олон зүйлийг үйлдсэн билээ.

10 Гэсэн хэдий ч, их “тарчлалын эцэст, Их Эзэн миний гуйлтуудыг сонссон, мөн миний залбирлуудад хариулсан, мөн намайг ^бта нараас олныг нь түүний үнэн мэдлэгт авчрах өөрийн мутар дахь зэмсэг болгосон бөлгөө.

11 Гэсэн хэдий ч, үүгээр би бахархахгүй, учир нь би бол өөрөөрөө бахархахаар зохистой нь биш.

12 Мөн эдүгээ би та нарт хэлье, та нар хаан Ноад дарамтлуулж байсан, мөн түүний, мөн түүний санваартнуудын боолчлолд байсан, мөн тэднээр алдаст хүргэгдсэн; тиймийн тул та нар

алдсын “хүлгээр хүлэгдсэн байсан бөлгөө.

13 Мөн эдүгээ та нар Бурханы хүчээр эдгээр хүлээснээс. Тийм ээ, бүр хаан Ноагийн мөн түүний хүмүүсийн гараас, мөн түүнчлэн алдсын хүлээснээс, чөлөөлөгдсөн шиг; тэрчлэн та нар чөлөөлөгдсөн энэ “эрх чөлөөндөө ^ббат зогсож, мөн та нарын дээр хаан байх “ямар ч хүнд итгэхгүй байгаасай хэмээн хүснэ би.

14 Мөн түүнчлэн түүний замуудаар замнан мөн зарлигуудыг нь дагадаг, Бурханы хүн байхаас бусдаар бол та нар өөрсдийн “багш мөн тохинуулагч болгохоор хэнд ч бүү итгэ.

15 Тийн Алма өөрсдийн дунд “зөрчилдөөнгүй байхын тулд хүн бүр хөршөө өөрийн адил ^бхайрлах ёстой хэмээн өөрийн хүмүүст заав.

16 Мөн эдүгээ, Алма тэдний “дээд санваартан байв, тэрээр тэдний сүмийг үндэслэгч байсны учир буюу.

17 Мөнхүү улиран тохиох дор номлох эсвэл багшлах “эрх мэдлийг Бурханаас бус аваас түүгээр дамжуулан хэн ч хүлээн авдаггүй. Тиймийн тул тэр тэдний бүх санваартнуудыг мөн бүх багш нарыг нь адислан томилов; мөн тэд шударга бус аваас нэг нь ч адислан томилогдоогүй бөлгөө.

23 7a Мозая 27:3–5.

9a Сур. үгс 16:12;
Мозая 11:1–15.

б Мозая 17:1–4.

10a С ба Г 58:4.

б Мозая 18:35.

12a 2 Ниф. 28:19–22.

13a су Эрх чөлөө.

б Гал. 5:1.

в Мозая 29:13.

14a Мозая 18:18–22.

15a 3 Ниф. 11:28–29.

б су Хайр.

16a Мозая 26:7.

17a су Эрх мэдэл;

Санваартан.

18 Тиймийн тул тэд өөрсдийн хүмүүсийг харж хандсан, мөн тэднийг зөв шударгад хамаарах зүйлүүд дээр дэмжин “асарсан болой.

19 Мөнхүү улиран тохиох дор тэд уг нутагт үлэмж дэгжиж эхлэв; мөн тэд уг нутгийг Хилам гэж нэрлэв.

20 Мөнхүү улиран тохиох дор тэд Хиламын нутагт өнөржин мөн үлэмж дэгжив; мөн тэд нэгэн хот барьж, мөн үүнийг Хиламын хот хэмээн нэрлэв.

21 Гэсэн хэдий ч Их Эзэн өөрийн хүмүүсийг “зэмлэх нь зүйд нийцэх бөлгөө; тийм ээ, тэрээр тэдний ^бтэвчээр мөн тэдний итгэлийг сорьдог билээ.

22 Гэсэн хэдий ч — түүнд “найдлага тавих хэн боловч мөнхүү тэр нь эцсийн өдөр ^бөргөмжлөгдөх болно. Тийм ээ, мөн энэ хүмүүсийн хувьд тийн байв.

23 Учир нь болгоогтун, тэд боолчлолд оруулагдсан байв, мөн Их Эзэн тэдний Бурхан, тийм ээ, бүр Абрахамын Исаакийн мөн Иаковын Бурханаас өөр хэн ч тэднийг чөлөөлж чадахгүйг би та нарт үзүүлэх болно.

24 Мөнхүү улиран тохиох дор тэрээр тэднийг чөлөөлсөн, мөн өөрийн их хүчийг тэрээр тэдэнд үзүүлсэн билээ, мөн тэдний баясал агуу их байв.

25 Учир нь болгоогтун,

улиран тохиох дор тэд Хиламын нутагт байхад, тийм ээ, Хиламын хотод, газар боловсруулж байх үед, болгоогтун леменчүүдийн их цэрэг нутгийн хилийн дотор орж ирэв.

26 Эдүгээ улиран тохиох дор Алмагийн ах дүүс талбайгаасаа зугтаж, мөн Хиламын хотод нэгдэн цугларцгаав; мөн тэд леменчүүд үзэгдсэний улмаас маш их айсан ажээ.

27 Гэвч Алма урагшлан мөн тэдний дунд зогсоод, мөн тэд айх ёсгүй, харин тэд Их Эзэн Бурханаа санах ёстой мөн тэрээр тэднийг чөлөөлнө хэмээн ухуулав.

28 Тиймийн тул тэд айдсаа дарж, мөн тэднийг, мөн тэдний эхнэрүүдийг, мөн тэдний хүүхдүүдийг хэлтрүүлэхийн тулд леменчүүдийн зүрхийг уяраахыг тэд Их Эзэнээс гуйж эхлэв.

29 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн леменчүүдийн зүрх сэтгэлийг уяраасан болой. Мөн Алма мөн түүний ах дүүс урагшлан мөн өөрсдигөө тэдний гарт өгөв; мөн леменчүүд Хиламын нутгийг эзэмшилдээ авав.

30 Эдүгээ хаан Лимхайн хүмүүсийн араас мөрдсөн леменчүүдийн их цэрэг олон хоногийн турш аглаг буйдад төөрсөн аж.

31 Мөн болгоогтун, тэд хаан Ноагийн мөнөөх санваартнуудыг, Амюлон гэж тэдний нэрлэсэн тэр нутагт олжээ;

18а 1 Тим. 4:6.
21а Хил. 12:3;
С ба Г 98:21.

су Зэмлэх, Зэмлэл.
б су Тэвчээр.
22а су Итгэл.

б 1 Ниф. 13:37.

мөн тэд Амюлоны нутгийг эзэмшиж эхлэн мөн газар боловсруулж эхэлсэн байв.

32 Эдүгээ тэдгээр санваартнуудын удирдагчийн нэр нь Амюлон байв.

33 Мөнхүү улиран тохиох дор Амюлон леменчүүдээс гуйв; мөн тэрээр түүнчлэн леменчүүдийн “охид болох эхнэрүүдээ эр нөхрүүдийг нь устгахгүй байхыг ах дүүсээс нь гуйлгахаар урагш илгээв.

34 Мөн леменчүүд Амюлон болон түүний ах дүүсийг “өрөвдөж, мөн тэднийг устгасангүй, тэдний эхнэрүүдийн учир бөлгөө.

35 Мөн Амюлон мөн түүний ах дүүс леменчүүдтэй нэгдэв, мөн тэд Нифайн нутгийг хайн аглаг буйдад аялж байх үедээ Алма болон түүний ах дүүсийн эзэмшиж байсан Хиламын нутгийг олж мэдэв.

36 Мөнхүү улиран тохиох дор хэрэв тэд Нифайн нутагт хүргэх замыг тэдэнд зааж өгвөл тэд амийг нь мөн тэдний эрх чөлөөг өгөх болно хэмээн леменчүүд Алма болон түүний ах дүүст амласан буюу.

37 Гэвч Алма тэдэнд Нифайн нутагт хүрэх замыг зааж өгсний дараа леменчүүд амлалтаа биелүүлсэнгүй; харин тэд Алма болон түүний ах дүүсийн дээр Хиламын нутгийн эргэн тойронд “харуулууд суулгав.

38 Мөн тэдний бусад нь Нифайн нутгийн зүг одов; мөн

тэдний нэг хэсэг нь Хиламын нутагт буцаж ирсэн аж, мөн түүнчлэн уг нутагт үлдээгдсэн харуулуудын эхнэр мөн хүүхдүүдийг өөрсөдтэйгээ авчирсан бөлгөө.

39 Мөн леменчүүдийн хаан Хиламын нутагт байсан өөрийн хүмүүсийн хаан бас захирагч байхыг Амюлонд зөвшөөрөв; гэсэн хэдий ч тэрээр леменчүүдийн хааны таалалд үл нийцэх ямар ч зүйлийг хийх хүч үгүй бөлгөө.

БҮЛЭГ 24

Алма болон түүний хүмүүсийг Амюлон хавчин дарлав — Хэрэв тэд залбирвал тэд үхэлд хүргэгдэх байв — Их Эзэн тэдний ачааг хөнгөн мэт санагдуулав — Тэрээр тэднийг боолчлолоос чөлөөлж, мөн тэд Зарахемлад эргэж ирэв. Ойролцоогоор мээ 145–120 он.

Мөнхүү улиран тохиох дор Амюлон леменчүүдийн хааны мэлмийд тааллыг олов; тиймийн тул, леменчүүдийн хаан түүнд болон түүний ах дүүст, хүмүүсийнхээ дээр. Тийм ээ, бүр Шиломын нутагт байсан, мөн Шиломын нутагт, мөн Амюлоны нутагт байсан тэр хүмүүсийн дээр багшаар томилогдсон байхыг зөвшөөрчээ.

2 Учир нь леменчүүд эдгээр бүх нутгийг эзэмшилдээ авсан байв; тиймийн тул, леменчүүдийн хаан эдгээр бүх

нутгийн дээр хаадыг томилсон бөлгөө.

3 Мөн эдүгээ леменчүүдийн хааны нэр нь Лемен хэмээн, эцгийнхээ нэрээр нэрлэгдсэн байв; мөн тиймийн тул тэрээр хаан Лемен гэж нэрлэгдсэн ажгуу. Мөн тэр олон тооны хүмүүсийн хаан байв.

4 Мөн тэрээр өөрийн хүмүүсээр эзэмшигдсэн нутаг бүрд Амюлоны ах дүүсээс багш нарыг томилов; мөн тийн Нифайн хэл леменчүүдийн бүх хүмүүсийн дунд заагдаж эхлэв.

5 Мөн тэд нэг нь нөгөөдөө найрсаг хүмүүс байв; гэсэн хэдий ч тэд Бурханыг мэддэггүй байлаа; бас Амюлоны ах дүүс, Их Эзэн Бурханыхаа талаар юу ч, бас Мосегийн хуулийг ч тэдэнд заасангүй; Абинадайн үгсийг ч тэдэнд заасан нь үгүй бөлгөө;

6 Гэвч тэд өөрсдийн цэдгийг хадгалбал зохихыг мөн тэд нэг нь нөгөөдөө бичиж болохыг заав.

7 Мөн тийн леменчүүд баялгаар арвижиж эхлэв, мөн бие биетэйгээ худалдаа хийж мөн хүчирхэгжиж эхлэв, мөн дэлхийн ухааны хувьд зальтай мөн мэргэн, тийм ээ, маш их зальтай, ах дүүсийнхээ дунд л биш бол ёс бус муу бүхэнд мөн дээрэм тонуулд баяссан хүмүүс болж эхлэв.

8 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма болон түүний ах дүүсийн дээр Амюлон “эрх дархыг үзүүлэн, мөн тэднийг

хавчиж эхлэн, мөн хүүхдүүдээрээ тэдний хүүхдүүдийг хавчин дарлуулж байв.

9 Учир нь Алмаг, тэрээр хааны санваартнуудын “нэг байсныг мөн тэр Абинадайн үгсэд итгэсэн нь тэр байсныг бас хааны өмнөөс хөөгдсөнийг Амюлон мэдэж байв, мөн тиймийн тул тэр түүнд хилэгнэж байлаа; учир нь тэр хаан Лемений харъяат байв, гэсэн хэдий ч тэр тэдний дээр эрх дархаа үзүүлж, мөн тэдэнд ⁶үүрэг ажил өгч, мөн тэднийг харгалзах хянагчдыг томилжээ.

10 Мөнхүү улиран тохиох дор тэдний зүдгүүрүүд аймшигтай их байсан тул тэд Бурханд хүчтэйгээр залбиран гуйж эхэлсэн ажээ.

11 Мөн тэд өөрсдийн гуйлтуудыг зогсоох ёстой хэмээн Амюлон тэдэнд зарлиг болов; мөн тэрээр Бурханыг дуудсан хэнийг боловч үхэлд хүргэхээр тэднийг харгалзах харуулуудыг тэдний дээр тавилаа.

12 Мөн Алма болон түүний хүмүүс Их Эзэн Бурхандаа дуу хоолойгоо өргөсөнгүй, гэвч зүрх сэтгэлээ түүнд “юүлж байсан болой; мөн тэрээр тэдний зүрх сэтгэл дэх бодлуудыг мэдэж байв.

13 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний дуу хоолой тэдний зүдгүүрт үед ирж, өгүүлсэн нь: Тэргүүнээ өргөцгөө мөн тайтгарагтун, учир нь надад хийсэн та нарын гэрээний тухай би мэднэ; мөн өөрийн

хүмүүстэй гэрээ хийж мөн тэднийг боолчлолоос чөлөөлөх болно би.

14 Мөн та нарын мөрөн дээр тавигдах ачаануудыг, бүр тэдгээрийг нуруун дээрээ байгааг ч мэдрэхгүй болтол, бүр та нарыг боолчлолд байх үед би түүнчлэн хөнгөлнө; мөн та нар цаашид миний “гэрчлэгчид болон зогсох болно, мөн та нар, Их Эзэн Бурхан би өөрийн хүмүүст тэдний “зүдгүүрт үед зочилдгийг та нар гарцаагүй мэдэж болохын би үүнийг хийх болно.

15 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор Алма болон түүний ах дүүсийн дээр тавигдаж асан ачаанууд хөнгөлөгдсөн байлаа; тийм ээ, тэд “ачаагаа амархан дааж чадахын тулд Их Эзэн тэднийг “хүчирхэгжүүлсэн билээ, мөн тэд баяртайгаар мөн “тэвчээртэйгээр Их Эзэний бүх тааллуудад захирагдсан болой.

16 Мөнхүү улиран тохиох дор тэдний итгэл мөн тэдний тэвчээр тийм агуу байсан учир Их Эзэний дуу хоолой тэдэнд дахин ирж, өгүүлсэн нь: Тайтгарагтун, учир нь маргааш би та нарыг боолчлолоос чөлөөлөх болно.

17 Мөн тэрээр Алмад: Чи энэ хүмүүсийн өмнө явах болно, мөн би чамтай хамт явж мөн энэ хүмүүсийг “боолчлолоос чөлөөлөх болно гэж хэлэв.

18 Эдүгээ улиран тохиох дор

Алма болон түүний хүмүүс шөнийн цагаар мал сүргээ, мөн түүнчлэн үр тарианаасаа, нэгтгэн цуглуулжээ; тийм ээ, бүр бүх шөнийн турш тэд мал сүргээ нэгтгэн цуглуулав.

19 Мөн өглөө нь Их Эзэн лемэнчүүдийн дээр “гүн нойр ирүүлж, тийм ээ, мөн тэдний бүх хянагчид гүн нойронд автагдсан байв.

20 Мөн Алма болон түүний хүмүүс аглаг буйд тийш одов; мөн тэд өдөржингөө аялаад, нэгэн хөндийд майхнуудаа босгов, мөн тэд уг хөндийг Алма гэж нэрлэв, учир нь тэрээр аглаг буйдад тэдний замыг удирдсан бөлгөө.

21 Тийм ээ, мөн тэр тэдэнд нигүүлсэнгүй байж мөн тэдний ачаануудыг хөнгөлж, мөн тэднийг боолчлолоос чөлөөлсөн учир тэд Алмагийн хөндийд Бурханд “талархлаа уудлан илэрхийлэв; учир нь тэд боолчлолд байж, мөн Их Эзэн Бурханаас нь өөр хэн ч тэднийг чөлөөлж чадахгүй байлаа.

22 Мөн тэд Бурханд талархал илэрхийлж, тийм ээ, тэдний бүх эрчүүд мөн тэдний бүх эмэгтэйчүүд мөн ярьж чадах тэдний бүх хүүхдүүд Бурханаа магтахад дуу хоолойгоо өргөсөн ажээ.

23 Мөн эдүгээ Их Эзэн Алмад: Чи яарагтун мөн өөрийгөө бас энэ хүмүүсийг энэ

14а су Гэрч.

б су Дайсан.

15а Алма 31:38; 33:23.

б Мат. 11:28–30.

в С ба Г 54:10.

су Тэвчээр.

17а су Боолилал.

19а 1 Сам. 26:12.

21а су Талархалтай,

Талархах, Талархал өргөх.

нутгаас авч гар, учир нь леменчүүд сэрсэн мөн чамайг мөшгөж байна; тиймийн тул энэ нутгаас гарцгаа, мөн би леменчүүдийг энэ хөндийд зогсоох болно, тэгснээр тэд энэ хүмүүсийг мөшгөхөөр цааш явахгүй хэмээв.

24 Мөнхүү улиран тохиох дор тэд уг хөндийгөөс одож, мөн аглаг буйдад аянаа хөөв.

25 Мөн тэд аглаг буйдад арванхоёр хоног байсны дараа тэд Зарахемлагийн нутагт хүрч ирэв; мөн хаан Мозая тэднийг түүнчлэн баяр хөөртэйгөөр угтаж авчээ.

БҮЛЭГ 25

Зарахемла дахь Мюликийн удам нифайчууд болов—Тэд Алмагийн болон Зенифийн хүмүүсийн талаар мэдэв—Лимхай болон түүний бүх хүмүүст Алма баптисм хүртээв—Бурханы сүм байгуулах эрх мэдлийг Мозая Алмад олгов. Ойролцоогоор мө 120 он.

Мөн эдүгээ хаан Мозая бүх хүмүүсийг нэгдэн цугларцгаах болгов.

2 Эдүгээ Нифайн хүүхдүүд, өөрөөр хэлбэл Нифайн удам болох тэд, “Мюликийн болон аглаг буйдад түүнтэй хамт ирсэн тэдний удам болох⁶Зарахемлагийн хүмүүс шиг тийм олон байсангүй.

3 Мөн Нифайн хүмүүс мөн Зарахемлагийн хүмүүс нийлээд ч леменчүүд шиг тийм

олон байсангүй; тийм ээ, тэд тооных нь хагаст ч хүрэхгүй байв.

4 Мөн эдүгээ Нифайн бүх хүмүүс нэгдэн чуулж, мөн түүнчлэн Зарахемлагийн бүх хүмүүс, мөн тэд хоёр хэсэгт цугларцгааж байв.

5 Мөнхүү улиран тохиох дор Зенифийн цэдгүүдийг Мозая өөрийн хүмүүст уншиж мөн уншигдахаар болгов; тийм ээ, тэд Зарахемла нутгийг орхисон тэр цагаас тэднийг эргэж ирснийг хүртэлх Зенифийн хүмүүсийн цэдгүүдийг тэрээр уншив.

6 Мөн түүнчлэн тэд Зарахемлагийн нутгийг орхисон цагаас тэд дахин эргэж ирснийг хүртэлх Алма болон түүний ах дүүсийн мөн тэдний бүх зүдгүүрийн шастирыг тэрээр уншсан бөлгөө.

7 Мөн эдүгээ, Мозая цэдгүүдийг уншихаа төгсгөл болгосны дараа, нутагтаа үлдсэн түүний хүмүүс гайхаж мөн бахдан догдолсон ажээ.

8 Учир нь тэд юу бодохоо мэдсэнгүй; учир нь тэд “боолчлолоос чөлөөлөгдсөн тэднийг хараад тэд үлэмж агуу баяр хөөрөөр дүүргэгдсэн байв.

9 Мөн түүнчлэн, тэд леменчүүдэд алагдсан ах дүүсээ дурсахдаа тэд харамслаар дүүрэн байв, мөн бүр харамслын их нулимс асгаруулсан буюу.

10 Мөн түүнчлэн, тэд Бурханы эн тэргүүний сайн сайхан, мөн Алма болон түүний ах дүүсийг леменчүүдийн

гараас мөн боолчлолоос чөлөөлсөн түүний хүчний тухай бодохдоо, тэд дуу хоолойгоо өргөн мөн Бурханд талархал илэрхийлэв.

11 Мөн түүнчлэн, тэд өөрсдийнх нь ах дүүс асан леменчүүд, тэдний нүгэлт мөн бохирдсон байдлын тухай бодохдоо тэдний “бодгалиудын аз жаргалын төлөө” зовлон мөн тарчлалаар дүүргэгдэв.

12 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн охидыг эхнэр болгон авцгаасан Амюлон болон түүний ах дүүсийн хүүхдүүд эцгүүдийнхээ үйлүүдийг үл таашааж, мөн тэд эцгүүдийнхээ нэрээр цаашид дуудагдмааргүй байсан аж, тиймийн тул тэд Нифайн хүүхдүүд гэж дуудагдаж болохын тулд мөн нифайчууд гэж нэрлэгдэгсдийн дунд тоологдож болохын тулд өөрсөд дээрээ Нифайн нэрийг авчээ.

13 Мөн эдүгээ Зарахемлагийн бүх хүмүүс нифайчуудтай хамт “тоологдож байв, мөн энэ нь уг хаант улс Нифайн удам байсан тэднээс бусад хэний ч мэдэлд үл шилжүүлэгдэж байсны учир болой.

14 Мөн эдүгээ улиран тохиох дор Мозая хүмүүст ярих мөн уншихаа төгсгөл болгоод, тэрээр Алмаг түүнчлэн хүмүүст ярихыг хүсэв.

15 Мөн тэд том хэсгүүд болон нэгдэн чуулж байх үед

Алма тэдэнд ярьсан болой, мөн тэрээр хүмүүст наманчлал мөн Их Эзэнд итгэх итгэлийг номлон нэг хэсгээс нөгөөд явав.

16 Мөн тэрээр Лимхайн мөн түүний ах дүүсийн боолчлолоос чөлөөлөгдсөн тэдгээр бүх хүмүүст, тэднийг чөлөөлсөн нь Их Эзэн байсныг тэд санах ёстой хэмээн ухуулав.

17 Мөнхүү улиран тохиох дор Алма хүмүүст олон зүйлийг зааж, мөн тэдэнд ярихаа төгсгөл болгосны дараа, хаан Лимхай баптисм хүртэх хүсэлтэй байжээ; мөн түүний бүх хүмүүс түүнчлэн баптисм хүртэх хүсэлтэй байв.

18 Тиймийн тул, Алма урагшлан усанд орж мөн тэдэнд “баптисм хүртээв; тийм ээ, тэрээр ах дүүстээ” Мормоны Усанд баптисм хүртээсний адил тийм маягаар тэдэнд баптисм хүртээв; тийм ээ, мөн түүний баптисм хүртээсэн бүхэн Бурханы сүмд хамаарагдсан болой; мөн энэ нь Алмагийн үгсэд итгэсэн тэдний итгэлийн учир бөлгөө.

19 Мөнхүү улиран тохиох дор хаан Мозая Зарахемлагийн бүх нутаг даяар сүмүүд байгуулж болохыг Алмад зөвшөөрөв; мөн сүм бүрийн дээрх санваартнууд болон багш нарыг томилох “хүчийг түүнд өгөв.

20 Эдүгээ бүгд нэг багшаар удирдагдаж чадахааргүй тийм олон хүн байсан учир энэ нь

11а су Хүн—Хүний үнэ цэнэ.
б Мозая 28:3–4;

Алма 13:27.
13а Омнай 1:19.
18а Мозая 21:35.

б Мозая 18:8–17.
19а су Санваартан.

хийгдсэн болой; бас тэд Бурханы үгийг нэг цугларалтанд бүгд анхааран сонсож чадахааргүй байв;

21 Тиймийн тул тэд өөрсдөө сүм хэмээн нэрлэгдэх өөр өөр хэсгүүдэд цугларцгаав, сүм болгон өөр өөрийн санваартан мөн өөр өөрийн багш нартай, мөн санваартан бүр Алмагийн амаар түүнд өгөгдсөний дагуу үгийг номлож байв.

22 Мөн тийн, тэнд олон сүм байсан хэдий ч тэд бүгд нэг “сүм байв, тийм ээ, бүр Бурханы сүм болой; учир нь наманчлал хийгээд Бурханд итгэхээс өөр юу ч бүх сүмд номлогддоггүй байв.

23 Мөн эдүгээ Зарахемлагийн нутагт долоон сүм байв. Мөнхүү улиран тохиох дор өөрсдийн дээр “Христийн буюу Бурханы нэрийг авах хүсэлтэй байсан хэн боловч, тэд Бурханы сүмүүдэд нэгдэв;

24 Мөн тэд Бурханы “хүмүүс гэж нэрлэгдэв. Мөн Их Эзэн тэдний дээр Сүнсээ юүлж, мөн тэд адислагдан, уг нутагт дэгжсэн бөлгөө.

БҮЛЭГ 26

Сүмийн олон гишүүн үл итгэгчдээр нүгэлд удирдагдав—Алмад мөнх амьдрал амлагдав—Наманчилж мөн баптисм хүртсэн тэд өршөөл хүртэнэ—Алмад

мөн Бурханд буруугаа тоочсон нүгэл үйлдсэн сүмийн гишүүд өршөөгдөх болно; эс бөгөөс тэд Сүмийн хүмүүсийн дунд тоологдох нь үгүй. Ойролцоогоор мээ 120–100 он.

Эдүгээ улиран тохиох дор хаан Бенжаминьн үгсийг ойлгож чадахгүй нь өсвөр үеийнхнээс олон байв, учир нь түүнийг өөрийн хүмүүст ярьж байх тэр цагт тэд бяцхан хүүхдүүд байжээ; мөн тэд эцэг өвгөдийнхөө уламжлалд итгэсэн нь үгүй.

2 Тэд үхэгсдийн амилуулалтын талаар яригдсан зүйлд итгэсэнгүй, бас тэд Христийн ирэлтийн талаар ч итгэсэн нь үгүй.

3 Мөн эдүгээ итгэлгүйнхээ учир тэд Бурханы үгийг “ойлгож чадсангүй; мөн тэдний зүрх сэтгэл хатуурсан байв.

4 Мөн тэд баптисм хүртээгүй байв; бас сүмд нэгдсэн нь ч үгүй. Мөн тэд сүсэг бишрэлийнхээ хувьд тусгаар хүмүүс байж, бүр өөрсдийн “эгэл мөн нүгэлт байдалдаа, мөн тэр чигээр үлдэв; учир нь тэд Их Эзэн Бурханаа дууддаггүй байв.

5 Мөн эдүгээ Мозаягийн засаглалын үед тэд Бурханы хүмүүсийн тооны хагаст нь ч хүрэхгүй байв; гэвч гишүүдийн дундах “зорчилдөөний улмаас тэд илүү олон тоотой болов.

22a Мозая 18:17.

23a су Есүс Христ—
Өөрсөд дээрээ
Есүс Христийн

нэрийг авах.

24a су Гэрээ.

26 3a су Мэдлэг.

4a су Эгэл хүн.

5a су Урвалт; Уруу
таталт.

6 Учир нь, улиран тохиох дор тэд бялдууч үгсээрээ сүмд байгсдаас олныг мэхэлж, мөн тэднийг олон нүгэл үйлдэхэд хүргэсэн аж; тиймийн тул сүмд байж нүгэл үйлдсэн тэд сүмээр “зэмлэгдэх ёстой нь зайлшгүй болов.

7 Мөнхүү улиран тохиох дор тэд санваартнуудын өмнө авчрагдаж, мөн багш нараар санваартнуудад хүргэгдсэн байв; мөн санваартнууд тэднийг “дээд санваартан асан Алмагийн өмнө авчирсан бөлгөө.

8 Эдүгээ хаан Мозая сүмийн дээрх эрх мэдлийг Алмад өгчээ.

9 Мөнхүү улиран тохиох дор Алма тэдний талаар мэдээгүй байв; гэвч тэдний эсрэг олон гэрч байжээ; тийм ээ, хүмүүс босч мөн тэдний алдсын талаар ихийг гэрчилж байв.

10 Эдүгээ сүмд урьд нь ийм зүйл нэгээхэн ч тохиолдож байсангүй; тиймийн тул Алмагийн сэтгэл зовж, мөн тэр тэднийг хааны өмнө аваачигдахаар болгов.

11 Мөн тэрээр хаанд хэлэв: Болгоогтун, ах дүүсээрээ буруутгагдсан тэд, таны өмнө бидний авчирсан тэднээс олон нь энд байна; тийм ээ, мөн тэд төрөл төрлийн алдсуудыг хийсэн нь баригдсан бөлгөө. Мөн тэд алдсуудаа үл

наманчилна; тиймийн тул гэмт хэргүүдийнх нь дагуу та тэднийг шүүж болно хэмээн, бид тэднийг таны өмнө авчирсан билээ.

12 Гэвч хаан Мозая Алмад хэлэв: Болгоогтун, би тэднийг үл шүүнэ; тиймийн тул би тэднийг шүүхийн тулд таны гарт “шилжүүлбэ.

13 Мөн эдүгээ Алмагийн сэтгэл дахин зовов; мөн тэрээр явж мөн энэ хэргийн талаар юу хийх ёстойгоо Их Эзэнээс лавлав, учир нь Бурханы мэлмийд тэр бурууг хийхвий хэмээн айсан ажээ.

14 Мөнхүү улиран тохиох дор тэр бүхий л бодгалиа мөн зүрх сэтгэлээ Бурханд юүлсний дараа, Их Эзэний дуу хоолой түүнд ирж, хэлрүүн:

15 Адислагдсан болой чи, Алма, мөн “Мормоны Усанд баптисм хүртсэн тэд адислагдсан болой. Зөвхөн миний үйлчлэгч Абинадайн үгсэд “итгэсэн үлэмж итгэлийнхээ учир адислагдсан болой чи.

16 Мөн, чиний тэдэнд ярьсан зөвхөн тэр үгсэд итгэх үлэмж итгэлийнхээ учир адислагдсан болой тэд.

17 Мөн чи энэ хүмүүсийн дунд “сүм байгуулсны учир адислагдсан болой чи; мөн тэд тогтоогдох болно, мөн тэд миний хүмүүс байх болно.

18 Тийм ээ, миний “нэрийг

6а Алма 5:57–58; 6:3.
су Сэрэмжлэх,
Сэрэмжлүүлэг.
7а Мозая 29:42.
12а С ба Г 42:78–93.

15а Мозая 18:30.
б Мозая 17:2.
су Итгэл.
17а Мозая 25:19–24.
18а Мозая 1:11; 5:8.

су Есүс Христ—
Өөрсөд дээрээ Есүс
Христийн нэрийг
авах.

авахад бэлэн энэ хүмүүс адислагдсан болой; учир нь миний нэрээр тэд нэрлэгдэх болно; мөн тэд минийх болой.

19 Мөн чи зөрчигчийн талаар надаас лавласан учир, адислагдсан чи.

20 Чи бол миний үйлчлэгч; мөн чамд “мөнх амьдрал байх болно хэмээн би чамтай гэрээ хийе; мөн чи надад үйлчилж мөн миний нэрээр явах болно, мөн миний хонийг нэгтгэн цуглуулах болно.

21 Мөн миний дуу хоолойг сонсох тэр нь миний “хонь байх болно; мөн түүнийг та нар сүмд хүлээн авна, мөн түүнийг би түүнчлэн хүлээн авах болно.

22 Учир нь болгоогтун, энэ бол миний сүм; “баптисм хүртсэн хэн боловч наманчлалд баптисм хүртэх болно. Мөн та нарын хүлээж авах хэн боловч миний нэрэнд итгэх болно; мөн түүнийг би чөлөөтэйгөөр ^бөршөөх болно.

23 Учир нь дэлхийн нүглийг өөр дээрээ “авагч нь би билээ; учир нь тэднийг ^ббүтээсэн нь би билээ; мөн төгсгөл хүртэл итгэх түүнд баруун гар талдаа байрлахыг соёрхох нь би билээ.

24 Учир нь болгоогтун, миний нэрээр тэд нэрлэгдэнэ;

мөн хэрэв тэд намайг “мэдэх аваас тэд гарч ирэх болно, мөн миний баруун гар талдахь байрыг мөнхөд эзлэх болно.

25 Мөнхүү улиран тохиох дор “хоёр дахь бүрээ дуугарахад тэгээд намайг огт ^бмэдээгүй тэд урагш гарч мөн миний өмнө зогсох болно.

26 Мөн тэгээд би бол Их Эзэн тэдний Бурхан гэдгийг, би бол тэдний Гэтэлгэгч гэдгийг тэд мэдэх болно; гэвч тэд гэтэлгэгдэхээс татгалзсан болой.

27 Мөн тэгээд би тэднийг огт “мэдээгүй хэмээн айлдах болно; мөн тэд чөтгөр болон түүний элчүүдэд бэлтгэгдсэн ^бүүрдийн галд “хаягдах болно.

28 Тиймийн тул би та нарт хэлнэ, миний дуу хоолойг “сонсохгүй түүнийг, мөнхүү түүнийг та нар миний сүмд хүлээн авахгүй байх болно, учир нь түүнийг эцсийн өдөр би хүлээн авахгүй байх болно.

29 Тиймийн тул би чамд хэлнэ, Явагтун; мөн миний эсрэг зөрчил үйлдэх хэнийг боловч, түүнийг үйлдсэн тэр “нүглүүдийнх нь дагуу та нар ^бшүүх болно; мөн хэрэв тэр чиний мөн миний өмнө

20a су Сонгох;
Сонгогдогсод;
Мөнх амьдрал.

21a су Сайн Хоньчин.

22a 2 Ниф. 9:23.

су Баптисм,
Баптисм хүртээх.

б су Уучлах;

Нүглүүдийн
ангижрал.

23a су Гэтэлгэгч.

б су Бүтээх, Бүтээл.

24a Иохан 17:3.

25a С ба Г 88:99, 109.

б С ба Г 76:81–86.

27a Мат. 7:21–23.

б С ба Г 76:43–44.

в Лук 13:27.

28a 2 Ниф. 9:31;

С ба Г 1:14.

29a су Хариуцах,

Хариуцлага,

Хариуцлагатай.

б су Шүүх, Шүүлт.

нүглүүдээ ^атоочиж, мөн чин зүрхнийхээ угаас ^анаманчлах аваас, түүнийг та нар ^ауучлах болно, мөн түүнчлэн би түүнийг өршөөх болно.

30 Тийм ээ, мөн миний хүмүүс ^анаманчлах ^бболгонд би тэднийг миний эсрэг алдаануудад нь өршөөх болно.

31 Мөн та нар түүнчлэн нэг нэгнийхээ алдаануудыг ^ауучлах ёстой; учир нь үнэнээр би та нарт хэлнэ, наманчилж буйгаа хэлсээр байтал нь хөршийнхөө алдааг эс өршөөх тэр, мөнхүү тэр нь өөрийгөө буруутгалын дор авчирдаг бөлгөө.

32 Эдүгээ би чамд хэлнэ, Явагтун; мөн нүглүүдээ эс наманчлах хэн боловч тэр нь миний хүмүүсийн дунд тоологдох нь үгүй; мөн энэ цагаас хойшид энэ нь мөрдөгдөх болно.

33 Мөнхүү улиран тохиох дор Алма эдгээр үгсийг сонсоод тэдгээрийг өөртөө байлгаж болохын тулд, мөн сүмийн хүмүүсийг Бурханы зарлигуудын дагуу шүүж болохын тулд бичиж авсан бөлгөө.

34 Мөнхүү улиран тохиох дор Алма явж мөн алдаст баригдсан тэднийг Их Эзэний үгийн дагуу шүүв.

35 Мөн нүглүүдээ наманчил-

сан мөн тэдгээрийг ^ахүлээсэн хэнийг боловч, тэрээр тэднийг сүмийн хүмүүсийн дунд тоолсон ажгуу;

36 Мөн нүглүүдээ хүлээгээгүй мөн алдсуудаа наманчлаагүй тэд, хэн боловч сүмийн хүмүүсийн дунд тоологддоггүй байж, мөн тэдний нэрс ^аарилгагдсан байв.

37 Мөнхүү улиран тохиох дор Алма сүмийн бүх хэргүүдийг хянав; мөн тэд дахин амар амгалан байж мөн Бурханы өмнө хянамгайгаар алхаж, олныг хүлээн авч, мөн олонд баптисм хүртээн, сүмийн хэргүүдэд үлэмж дэгжиж эхлэв.

38 Мөн эдүгээ сүмийг удирдаж асан тэд болох Алма мөн түүний хамтран хөдөлмөрлөгчид хичээнгүйлэн явж, бүх зүйлд Бурханы үгсийг зааж, төрөл бүрийн зовлонгуудыг амсан, Бурханы сүмд хамаарагдаагүй тэд бүгдээр хавчигдан байж эдгээр бүх зүйлийг хийсэн болой.

39 Мөн тэд ах дүүсээ зэмлэв; мөн тэд түүнчлэн Бурханы үгээр, хүн бүр нүглүүдийнхээ дагуу, өөрөөр хэлбэл үйлдсэн тэр нүглүүддээ ^азэмлэгдэж байв, мөн тэд тасралтгүй ^бзалбирч, мөн бүх зүйлд ^аталархал илэрхийлж байхыг Бурханаар зарлиг болгуулсны учир болой.

29в 3 Ниф. 1:25.

су Хүлээн зөвшөөрөх,
Хүлээн зөвшөөрөлт.

г су Наманчлах,
Наманчлал.

д су Уучлах.

30а Езек. 33:11, 15–16;
Үйлс 3:19–20;

Мозая 29:19–20.

б Моро. 6:8.

31а 3 Ниф. 13:14–15;

С ба Г 64:9–10.

35а су Хүлээн

зөвшөөрөх, Хүлээн

зөвшөөрөлт.

36а Ег. 32:33; Алма 1:24.

су Амьдралын
Ном; Сүмээс хөөх.

39а су Сэрэмжлэх,
Сэрэмжлүүлэг.

б 2 Ниф. 32:8–9.

в су Талархалтай,
Талархах, Талархал
өргөх.

БҮЛЭГ 27

Мозая хавчлагыг хориглож мөн тэгш эрхийг дэмжив—Залуу Алма мөн Мозаягийн дөрвөн хүү Сүмийг устгахаар эрэлхийлэв—Тэнгэр элч үзэгдэж мөн хилэнцэт замаасаа гарахыг тэдэнд зарлиг болгов—Алма цочирдон хэлгүй мэт болгогдов—Бүх хүн төрөлхтөн авралыг олохын тулд дахин төрөх ёстой—Алма мөн Мозаягийн хөвгүүд баярт мэдээг тунхаглав. Ойролцоогоор мээ 100–92 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор үл итгэгчдээс сүмд учруулах хавчлагууд үлэмж их болсон учир сүмийнхэн уг хэргийн талаар удирдагчиддаа бувтналдан, мөн гомдоллож эхлэв; мөн тэд Алмад гомдоллов. Мөн Алма өөрсдийн хаан, Мозаяд байдлыг танилцуулав. Мөн Мозая санваартнуудтайгаа зөвлөв.

2 Мөнхүү улиран тохиох дор хаан Мозая үл итгэгчдийн хэн нь ч Бурханы сүмд харъяалагдсан тэднээс хэнийг ч “хавчих ёсгүй хэмээх тунхаг бичгийг эргэн тойрны нутаг даяар илгээв.

3 Мөн бүх сүмд тэдний дунд хавчлага байх ёсгүй, бүх хүмүүний дунд “эрх тэгш байдал байх ёстой гэсэн чанд зарлиг байв.

4 Ямар ч бардамнал бас ямар

ч ихэмсэглэл тэдний “амар амгаланд саад учруулахыг тэд зөвшөөрөх ёсгүй; хүн бүр хөршөө өөрийнхөө адил хүндэтгэж, өөрсдийгөө тэтгэхийн тулд өөрийн гараар хөдөлмөрлөх ёстой байв.

5 Тийм ээ, мөн тэдний бүх санваартнууд мөн багш нар өвчний, эсвээс их гачигдлын байдлаас өөр ямар ч нөхцөлд тэд өөрсдийгөө тэжээхээр өөрсдийн гараар “хөдөлмөрлөх ёстой; мөн эдгээр зүйлийг хийснээр Бурханы “ач ивээлд умбасан болой.

6 Мөн уг нутагт дахин их амгалан байж эхлэв; мөн хүмүүс маш олон тоотой болж эхлэв, мөн газрын гадаргуу дээр тархаж эхлэв, тийм ээ, өмнөдөд мөн умардад, дорнодод бас өрнөдөд, уг нутгийн бүх хэсгүүдэд том хотууд мөн тосгод барьсан бөлгөө.

7 Мөн Их Эзэн тэдэнд зочилж мөн тэднийг дэгжүүлэн, мөн тэд өнөр өтгөн хийгээд чинээлэг хүмүүс болов.

8 Эдүгээ Мозаягийн хөвгүүд үл итгэгчдийн дунд тоологдож байв; мөн түүнчлэн Алмагийн “хөвгүүдийн нэг нь тэдний дунд тоологдож байлаа, тэр эцгийнхээ адилаар Алма гэж нэрлэгдсэн байв; гэсэн хэдий ч, тэр маш ёс бус мөн “хиймлийг шүтэгч хүн болов. Мөн тэрээр олон үгтэй хүн байж, мөн хүмүүст

27 2a су Хавчих, Хавчлага.
3a Мозая 23:7; 29:32.
4a су Амар амгалан.

б су Хайр хүндэтгэл.
5a Мозая 18:24, 26.
б су Ач ивээл.
8a су Алма, Алмагийн

хүү.
б су Хиймэл шүтээн.

ихээхэн зусрыг ярьдаг байв; тиймийн тул тэрээр хүмүүсээс олныг нь өөрийн алдсуудын маягаар хийхийг удирдсан ажгуу.

9 Мөн тэрээр хүмүүсийн зүрх сэтгэлийг “хулгайлан; хүмүүсийн дунд их зөрөлдөөнийг үүсгэж; тэдний дээр өөрийн хүчийг үзүүлэх боломжийг Бурханы дайсанд олгож байсан учир тэрээр Бурханы сүмийн хөгжилд үлэмж том саад болов.

10 Мөн эдүгээ улиран тохиох дор тэрээр Бурханы сүмийг устгахаар явж байхад нь, тодруулбал тэр Мозаягийн хөвгүүдтэй сүмийг устгахыг, мөн Их Эзэний хүмүүсийг буруу замд удирдахыг эрэлхийлэн, Бурханы, эсвээс бүр хааны зарлигуудын эсрэг нууцаар явдаг байлаа —

11 Мөн та нарт миний хэлсэнчлэн, тэд Бурханыг “эсэргүүцэн явах зуур, болгоогтун, Их Эзэний ⁶тэнгэр элч тэдэнд “үзэгдэв; мөн тэрээр үүлэнд байсан мэтээр доошлон ирэв; мөн тэрээр тэдний дээр нь зогсож байсан газрыг доргиход хүргэсэн аянгын дуу лугаа адил дуу хоолойгоор ярив;

12 Мөн тэдний сүрдэн гайхсан нь маш их байснаас, тэд газарт унаж, тэгээд өөрсдөд нь ярьсан түүний үгсийг ойлгосонгүй.

13 Гэсэн хэдий ч тэр дахин хашгирч, хэлрүүн: Алма, бос мөн урагш зогс, та яагаад

Бурханы сүмийг хавчих болов? Учир нь: “Энэ бол миний сүм, мөн би үүнийг төвхнүүлэх болно; мөн миний хүмүүсийн зөрчлөөс өөр юу ч үүнийг буулгахгүй хэмээн Их Эзэн хэлж байна.

14 Мөн түүнчлэн, тэнгэр элч хэлэв: Болгоогтун, Их Эзэн өөрийн хүмүүсийн “залбирлуудыг, мөн түүнчлэн өөрийн үйлчлэгч, таны эцэг болох Алмагийн залбирлуудыг сонссон; учир нь та үнэний мэдлэгт авчрагдаж болохын тулд таны талаар их итгэлтэйгээр тэрээр залбирсан бөлгөө; тиймийн тул, энэ зорилгоор түүний үйлчлэгчдийн ⁶залбирлууд тэдний итгэлийнх нь дагуу хариулагдаж болохын тулд Бурханы хүч болон эрх мэдлийг танд итгүүлэхийн тулд ирлээ, би.

15 Мөн эдүгээ болгоогтун, та Бурханы хүчийг сөрж чадах уу? Учир нь болгоогтун, миний дуу хоолой газрыг доргиохгүй байна гэж үү? Мөн түүнчлэн та намайг өөрийнхөө өмнө харж чадаж байгаа бус уу? Мөн Бурханаас илгээгдсэн билээ, би.

16 Эдүгээ би танд хэлье: Явагтун, мөн Хеладын нутагт, мөн Нифайн нутагт эцэг өвгөд тань боолчлолд байсныг санагтун; мөн тэдний төлөө тэрээр ямар агуу зүйлүүдийг хийснийг сана; учир нь тэд боолчлолд байсан тэгээд тэрээр тэднийг

9а 2 Сам. 15:1–6.
11а су Эсэргүүцэл.
б су Тэнгэр элчүүд.

в Үйлс 9:1–9;
Алма 8:15.
13а су Есүс Христ—

Сүмийн Тэргүүн.
14а Алма 10:22.
б Морм. 9:36–37.

“чөлөөлсөн юм. Мөн эдүгээ би танд хэлнэ, Алма, өөрийн замаар яв, мөн тэдний залбирал хариулагдаж болохын тулд сүмийг устгахыг дахин бүү эрэлхийл, мөн та өөрөө зайлуулагдахыг хүссэн ч, үүнийг бүү хийгтүн.

17 Мөн эдүгээ улиран тохиох дор эдгээр нь Алмад ярьсан тэнгэр элчийн сүүлчийн үгс байв, мөн тэрээр одов.

18 Мөн эдүгээ Алма болон түүнтэй хамт байсан тэд газарт унав, учир нь тэдний сүрдэн гайхсан нь асар их байв; учир нь Их Эзэний тэнгэр элчийг тэд нүдээрээ харсан болой; мөн түүний дуу газрыг доргиох аянга лугаа адил байв; мөн Бурханы хүчнээс өөр юу ч газрыг доргион мөн хоёр тийш болон хуваагдах мэт чичиргэж чадахгүйг тэд мэдсэн бөлгөө.

19 Мөн эдүгээ Алмагийн сүрдэн гайхширсан нь маш их байсан учир тэрээр хэлгүй болов, амаа ч нээж чадахгүй байлаа; тийм ээ, тэрээр доройтон бүр гараа ч хөдөлгөж чадахгүй болжээ; тиймийн тул тэрээр түүн лугаа адил байсан тэднээр өргөгдөж, мөн арчаагүйгээр зөөгдөн, бүр эцгийнхээ өмнө хэвтүүлэгдэх хүртлээ буюу.

20 Мөн тэд түүний эцэгт өөрсдөд нь тохиолдсон бүгдийг тоочин хэлэв; мөн

түүний эцэг баясав, учир нь энэ бол Бурханы хүч байсныг тэрээр мэдэж байлаа.

21 Мөн тэрээр хүүд нь, мөн түүнчлэн түүнтэй байсан тэдэнд Их Эзэн юу хийснийг тэд гэрчилж болно хэмээн олон хүмүүнийг цуглуулав.

22 Мөн тэрээр санваартнуудыг нэгдэн чуулахаар болгов; тэрээр Алмагийн ам ярьж болохын тулд нээгдэж, мөн түүнчлэн түүний үе мөч хүчээ сэргээн авч болохын тулд—Бурханы сайн сайхан хийгээд алдар сууг мэдэж мөн харахаар хүмүүсийн нүд нээгдэж болохын тулд тэд мацаг барин, мөн Их Эзэн Бурхандаа хандан залбирч эхлэв.

23 Мөнхүү улиран тохиох дор тэд хоёр өдөр мөн хоёр шөнийн турш мацаг барьж, залбирсны дараа, Алмагийн үе мөчний хүч тамир сэргэж, мөн тэрээр дээш босоод, мөн тэднийг тайвшрахыг хүсэн тэдэнд ярьж эхлэв:

24 Учир нь, хэмээн тэрээр хэлж, би нүглүүдээ наманчилсан, мөн Их Эзэнээр “гэтэлгэгдсэн; болгоогтун би Сүнсээр төрлөө гэв.

25 Мөн Их Эзэн надад хэлэв: Бүх хүн төрөлхтөн, тийм ээ, эрчүүд мөн эмэгтэйчүүд, бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс “дахин төрөх ёстойд бүү гайх; тийм ээ, Бурханаар

16a Мозая 23:1–4.
24a 2 Ниф. 2:6–7.
су Гэтэлгэх,
Гэтэлгэгдэх,

Гэтэлгэл.
25a Ром 6:3–11;
Мозая 5:7;
Алма 5:14;

Моце 6:59.
су Дахин төрөх,
Бурханаас төрөх.

төрж, ⁶эгэл хийгээд унасан байдлаасаа зөв шударга байдалд орж ⁶өөрчлөгдөн, Бурханаар гэтэлгэгдэн, түүний хөвгүүд мөн охид болдог;

26 Мөн тийн тэд шинэ бүтээлүүд болдог; мөн үүнийг хийхгүйгээр, тэд Бурханы хаант улсыг өвлөж чадах “аргагүй бөлгөө.

27 Би та нарт хэлнэ, энэ нөхцөлд бус аваас, тэд зайлуулагдах ёстой; мөн үүнийг би мэднэ, учир нь би зайлуулагдах дөхлөө.

28 Гэсэн хэдий ч, их бэрхшээлийг туулж үхэх дөхөн наманчилсны дараа, Их Эзэн намайг нигүүлсэлдээ “үүрдийн шаталтаас шүүрч авах нь зохистой хэмээн үзжээ, мөн би Бурханаар төрлөө.

29 Миний бодгаль шаналлын гүн болон алдсын хүлээснээс гэтэлгэгдлээ. Би хамгийн харанхуй ангалд байсан; харин эдүгээ би Бурханы гайхамшигт гэрлийг харнам. Бодгаль минь мөнхийн зовлонд “тарчилж байв; гэвч би шүүрэгдлээ, мөн бодгаль минь цаашид дахин өвдөх нь үгүй.

30 Би өөрийн Гэтэлгэгчийг эсэргүүцсэн, мөн бидний эцэг өвгөдөөр яригдсаныг үгүйсгэсэн; харин эдүгээ тэр ирэх болно, мөн тэрээр өөрийн бүтээсэн бүтээл бүрийг санаана гэдгийг тэд урьдаас харж

болохын тулд тэр өөрийгөө бүгдэд үзүүлэх болно.

31 Тийм ээ, түүний өмнө “өвдөг бүхэн сөхөрч, мөн хэл бүхэн хүлээн зөвшөөрөх болно. Тийм ээ, бүх хүмүүн түүгээр ⁶шүүгдэхээр зогсох бүр тэрхүү эцсийн өдөр, тэгээд тэр бол Бурхан гэдгийг тэд хүлээн зөвшөөрнө; тэгээд “Бурхангүйгээр дэлхийд амьдрах тэд, тэдний дээрх үүрдийн шийтгэлийн шүүлт шударга болохыг хүлээн зөвшөөрнө; мөн тэд дагжин, мөн чичирч, мөн “бүхнийг ухаарах түүний мэлмийн харцнаас навтайх болно.

32 Мөн эдүгээ улиран тохиодор Алма болон Алмагийн хамт байсан тэд тэнгэр элч тэдэнд үзэгдсэн тэр цагт, энэ цагаас хойш хүмүүст сургаж эхлэв, мөн, бүх нутаг даяар аялан явж, үл итгэгчдэд ихээр хавчигдаж, тэдний олноор нь цохигдон, өөрсдийн сонссон мөн үзсэн тэр зүйлүүдээ бүх хүмүүнд тунхаглаж, мөн Бурханы үгийг их бэрхшээлийн дунд номлон байв.

33 Харин энэ бүгд байсан хэдий ч тэд сүмд их тайтгарлыг хайрласан болой, тэдний итгэлийг нь батлан, мөн тэсвэртэйгээр мөн ихэд шаргуугаар Бурханы зарлигуудыг дагахыг тэдэнд ухуулж байв.

34 Мөн тэдний дөрөв нь Мозаягийн хөвгүүд байв; мөн

25б су Тачаангуй,
Зуурдын.
в Мозая 3:19; 16:3.
26а Иохан 3:5.
28а 2 Ниф. 9:16.

29а Мозая 2:38.
31а Филип. 2:9–11;
Мозая 16:1–2;
С ба Г 88:104.
б су Есүс Христ—

Шүүгч.
в Алма 41:11.
г су Бурхан.

тэдний нэрс нь Аммон, мөн Аарон, мөн Омнер, мөн Химнай байв; эдгээр нь “Мозаягийн хөвгүүдийн нэрс байв.

35 Мөн тэд Зарахемлагийн бүх нутгаар аялж, мөн хаан Мозаягийн засаглал дор байх бүх хүмүүсийн дунд, бүх нүглүүдээ хүлээж, мөн үзсэн тэр бүх зүйлүүдээ тунхаглан, мөн өөрсдийг нь сонсохыг хүссэн бүхэнд бошиглалууд хийгээд судруудыг тайлбарлаж, сүмд учруулсан тэр бүх хор хөнөөлөө залруулахаар хичээж байв.

36 Мөн тийн тэд олныг үнэний мэдлэгт, тийм ээ, Гэтэлгэгчийнхээ мэдлэгт авчрахад Бурханы мутар дахь зэмсгүүд болов.

37 Мөн эдүгээ хичнээн их адислагдсан билээ тэд! Учир нь амар амгаланг тэд “тунхагласан болой;” баярт мэдээг тэд тунхагласан болой; мөн Их Эзэн хаанчилдгийг тэд хүмүүст зарлан мэдэгдсэн билээ.

БҮЛЭГ 28

Мозаягийн хөвгүүд леменчүүдэд номлохоор явав — Мозая хоёр үзмэрч чулуу хэрэглэн, жаредчуудын ялтсуудыг орчуулав. Ойролцоогоор мээ 92 он.

Эдүгээ улиран тохиох дор “Мозаягийн хөвгүүд эдгээр бүх зүйлийг хийсний дараа тэд өөрсөдтэйгөө цөөн тооны

хүмүүсийг авч мөн хаан эцэгтээ эргэж очив, мөн тэднийг, сонгож авсан тэдэнтэйгээ хамт, тэд сонссон зүйлүүдээ номлож, мөн тэд Бурханы үгийг өөрсдийн ахан дүүс, леменчүүдэд хүргэж болохын тулд ⁶Нифайн нутаг өөд явахыг зөвшөөрөөч хэмээн түүнээс хүсэв —

2 Тэднийг Их Эзэн Бурханых нь мэдлэгт тэд авчирч, мөн эцэг өвгөдийнх нь алдсыг тэдэнд ойлгуулж магадгүйн учир буюу; мөн Их Эзэн Бурханых нь тэдэнд өгсөн бүх нутагт зөрчилдөөнүүд дахин байхгүйн төлөө, тэд нэг нэгэнтэйгээ найрсаг болж болохын тулд, түүнчлэн Их Эзэн Бурхандаа баясахаар тэд хүргэгдэж болохын тулд, нифайчуудад хандсан тэдний “үзэн ядалтыг тэд анагааж магадгүйн учир болой.

3 Эдүгээ аврал бүтээл бүрд тунхаглагдвал зохино хэмээх хүсэл тэдэнд байв, учир нь тэд аль ч хүмүүний “бодгаль мөхнө гэдгийг” ⁶тэвчиж үл чадах байсан ажгуу; тийм ээ, бүр ямар нэгэн бодгаль “төгсгөлгүй тарчлалыг амсана гэдэг чухам тэрхүү бодлууд тэднийг чичирч мөн дагжихад хүргэсэн ажээ.

4 Мөн Их Эзэний Сүнс тэдний дээр тийн үйлдсэн болой, учир нь тэд “адгийн нүгэлтнүүд байв. Мөн Их Эзэн

34a су Аммон,
Мозаягийн хүү.

37a Иса. 52:7;
Моза 15:14–17.
су Номлох.
б су Сайн Мэдээ.

28 1a Мозая 27:34.
б Омнаи 1:12–13;
Мозая 9:1.

2a Иаков 7:24.

3a су Хүн—Хүний үнэ
цэнэ.

б Алма 13:27;
3 Ниф. 17:14;
Моце 7:41.

в Иаков 6:10;

С ба Г 19:10–12.

4a Мозая 27:10.

хязгааргүй ⁶нигүүлсэлдээ тэднийг хэлтрүүлбэл зохино хэмээн үзэв; гэсэн хэдий ч тэд алдсуудынхаа учир бодгалийн их тарчлалыг амсаж, тэд үүрд зайлуулагдахвий хэмээн ихэд зовж мөн айж байв.

5 Мөнхүү улиран тохиох дор Нифайн нутаг өөд явж болохын тулд тэд эцгээсээ олон хоног гуйсан аж.

6 Мөн хаан Мозая явж мөн тэр хөвгүүдээ үгийг номлохоор леменчүүдийн дунд явахыг нь зөвшөөрөх эсэхээ Их Эзэнээс лавлав.

7 Мөн Их Эзэн Мозаяд хэлэв: Тэднийг явахыг зөвшөөрөгтүн, учир нь олон нь тэдний үгсэд итгэх болно, мөн тэд мөнх амьдралыг авах болно; мөн би хөвгүүдийг чинь леменчүүдийн гараас “чөлөөлөх болно.

8 Мөнхүү улиран тохиох дор тэд хүссэнийхээ дагуу яван мөн хийж болно хэмээн Мозая зөвшөөрөв.

9 Мөн тэд леменчүүдийн дунд үгийг номлохоор яван аглаг буйд тийш “аянаа хөөв; мөн тэдний цаашдын үйлүүдийн ⁶шастирыг би хожим өгөх болно.

10 Эдүгээ хаант улсыг шилжүүлэх хүн хаан Мозаяд байсангүй, учир нь түүний хөвгүүдээс хаант улсыг хүлээн авах хэн нь ч байсангүй.

11 Гиймийн тул тэрээр Лимхайн гараар түүнд хүр-

гэгдсэн, Лимхайн хүмүүсээр олдсон “алтан ялтсууд дээр байсан цэдгүүдийг орчуулуулж мөн бичүүлсний дараа тэрээр ⁶гуулин ялтсууд, мөн түүнчлэн Нифайн ялтсууд дээр сийлбэрлэгдсэн цэдгүүдийг мөн Бурханы зарлигуудын дагуу өөрийн хадгалж мөн хамгаалж үлдээсэн бүх зүйлийг авчээ;

12 Мөн хүмүүсийнхээ агуу их зовнилын учир тэр үүнийг хийв; учир нь тэд устгагдсан тэдгээр хүмүүсийн талаар мэдэх хэмжээлшгүй хүсэлтэй байв.

13 Мөн эдүгээ тэрээр тал дугаргийн хоёр хүрээнд суулгасан тэрхүү хоёр “чулууны тусламжтайгаар орчуулав.

14 Эдүгээ эдгээр зүйлүүд эхлэлээс бэлтгэгдсэн ажээ, мөн хэлнүүдийг хөрвүүлэх зорилгын учир үеэс үед гардуулагдсан байв.

15 Мөн тэдгээр нь Их Эзэний мутраар хамгаалагдаж мөн хадгалагдан үлдсэн ажгуу, тэрээр өөрийн хүмүүсийн алдсууд мөн жигшүүрт хэргүүдийг уг нутгийг эзэмших бүтээл бүрд мэдүүлэхийн тулд бөлгөө.

16 Мөн эдгээр зүйлүүд өөрт нь байгаа хэн боловч, хуучин цагийн заншлаар “үзмэрч гэж нэрлэгдэх буюу.

17 Эдүгээ Мозая эдгээр цэдгүүдийг орчуулж дууссаны дараа, болгоогтун, энэ нь

46 су Нигүүлсэнгүй,
Нигүүлсэл.
7а Алма 19:22–23.
9а Алма 17:6–9.

б Алма 17–26.
11а су Алтан ялтсууд.
б су Гуулин ялтсууд.
13а су Урим ба

Туммим.
16а Мозая 8:13–18.
су Үзмэрч.

устгагдсан хүмүүсийн шастирыг өгүүлдэг, тэдний “устгагдсан үеэс урагш тэд ^багуу цамхаг барих хүртэл, Их Эзэн хүмүүсийн хэлийг ^вбудлиулж мөн тэд бүх дэлхийн гадаргуугаар нэг тархсан тэр цагт агуу, тийм ээ, мөн бүр тэр цагаас урагш Адамыг бүтээсэн цаг хүртэл бөлгөө.

18 Эдүгээ энэ шастир Мозагийн хүмүүсийг үлэмж гашуудахад хүргэв, тийм ээ, тэд харамслаар дүүрэн байв; гэсэн хэдий ч, тэр их мэдлэгийг тэдэнд өгсөн нь тэднийг баясгах бөлгөө.

19 Мөн энэхүү шастир хожим бичиглэгдэх болно; учир нь болгоогтун, энэ шастирт бичигдсэн зүйлийг бүх хүмүүс мэдэх нь чухал болой.

20 Мөн эдүгээ, би та нарт хэлсэнчлэн, хаан Мозая эдгээр зүйлийг хийснийхээ дараа, “гуулин ялтсуудыг, мөн өөрийн хадгалсан бүх зүйлийг тэрээр авсан аж, мөн тэдгээрийг Алмагийн хүү Алмагийн мэдэлд тэр шилжүүлэв; тийм ээ, бүх цэдэг, мөн түүнчлэн ^бхөрвүүлэгчдийг, мөн тэдгээрийг түүний мэдэлд шилжүүлж, мөн тэрээр тэдгээрийг ^вхамгаалж мөн хадгалан үлдээж, мөн түүнчлэн хүмүүсийн цэдгийг хөтөлж, бүр тэд Лихай Иерусалимыг орхисон тэр цагаас тэдгээр нь доош гардуулагдаж байсны адил тэдгээрийг

нэг үеэс нөгөөд гардуулж байхыг түүнд зарлиг болгов.

БҮЛЭГ 29

Хааны оронд шүүгчид сонгогдохыг Мозая санал болгов—Зөв шударга бус хаад өөрсдийн хүмүүсийг нүгэлд удирддаг—Залуу Алма хүмүүсийн саналаар ерөнхий шүүгчээр сонгогдов—Түүнчлэн тэрээр Сүмийн дээрх дээд санваартан байв—Ахмад Алма Мозая хоёр нас нөгчив. Ойролцоогоор мээ 92–91 он.

Эдүгээ Мозая үүнийг хийснийхээ дараа бүх нутаг даяар, бүх хүмүүсийн дунд, хэн тэдний хаан байвал зохих талаар тэдний хүслийг мэдэхийг хүсэн илгээв.

2 Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн санал ирж, өгүүлсэн нь: Бид таны хүү Аарон бидний хаан хийгээд бидний захирагч байхыг хүсч байна.

3 Эдүгээ Аарон Нифайн нутаг өөд явсан байв, тиймийн тул хаан түүний мэдэлд хаант улсыг шилжүүлж чадсангүй; Аарон ч хаант улсыг өөртөө авахыг хүссэнгүй; “Мозагийн хөвгүүдийн аль нь ч хаант улсыг өөрсөд дээрээ авахыг таалсангүй ажгуу.

4 Тиймийн тул хаан Мозая хүмүүсийн дунд дахин илгээж; тийм ээ, бүр бичиглэгдсэн үгийг хүмүүсийн дунд илгээв. Мөн эдгээр нь

17а Мозая 8:7–12.
б Ифер 1:1–5.
в Эхл. 11:6–9.
20а Алма 37:3–10.

б су Урим ба Туммим.
в су Судрууд—Хадгалагдсан

судрууд.
29 За Мозая 27:34.

бичигдсэн тэрхүү үгс буюу, өгүүлсэн нь:

5 Болгоогтун, Ай хүмүүс та нар минь, өөрөөр хэлбэл ах дүүс минь, учир нь би та нарыг тийнхүү хүндэтгэн үзнэ, та нар эрэгцүүлэхийн тулд дуудагдсан тэрхүү байдлыг эрэгцүүлж үзвэл зохино хэмээн би хүснэ—учир нь та нар “хаантай байх хүсэлтэй буюу.

6 Эдүгээ хаант улс зүй ёсоор харьяалагдах ёстой тэр нь татгалзлаа, мөн хаант улсыг тэр өөр дээрээ эс авах болно гэдгийг би та нарт зарлая.

7 Мөн эдүгээ хэрэв түүний оронд өөр нэг нь томилогдох аваас, болгоогтун би та нарын дунд зөрчилдөөн гарах вий хэмээн айна. Мөн хэн мэдэх билээ, энэ хаант улс харьяалагдах ёстой байсан миний хүү, зангаа хувирган уурлаж мөн энэ хүмүүсийн нэг хэсгийг өөрийн хойноос дагуулж одох вий, тэгвэл та нарын дунд дайнууд мөн зөрчилдөөнүүд үүсч, тэгснээр их цус урсан, мөн Их Эзэний замыг гажуудуулахад хүргэн, тийм ээ, мөн олон хүмүүний бодгалийг устгаж болзошгүй буюу.

8 Эдүгээ би та нарт хэлнэ, ухаалаг байцгаая мөн эдгээр зүйлийг эргэцүүлэн бодоцгооё, учир нь миний хүүг устгах эрх бидэнд үгүй, мөн хэрэв түүний оронд өөр нэг нь тохоогдвол түүнийг устгах эрх ч бас бидэнд үгүй.

9 Мөн хэрэв миний хүү бардамнал мөн хоосон зүйлүүддээ дахин эргэх аваас тэр хэлсэн тэр зүйлүүдээсээ буцан, мөн хаант улс дахь өөрийн эрхийг шаардах нь, түүнийг мөн түүнчлэн энэ хүмүүсийг их нүгэл үйлдэхэд хүргэх бөлгөө.

10 Мөн эдүгээ ухаалаг байцгаая мөн эдгээр зүйлийг урьдаас харцгаая, мөн энэ хүмүүсийн амар амгаланг тогтоох зүйл хийцгээе.

11 Тиймийн тул би өөрийн өдрүүдийн үлдсэн хугацаанд та нарын хаан байх болно; гэсэн хэдий ч, манай хуулийн дагуу энэ хүмүүсийг шүүх “шүүгчдийг ⁶томилцгооё; мөн бид энэ хүмүүсийн хэрэг явдлыг шинээр журамлах болно, учир нь Бурханы зарлигуудын дагуу энэ хүмүүсийг шүүх мэргэн хүмүүсийг шүүгчид байхаар бид томилох болно.

12 Эдүгээ хүн хүнээр шүүгдсэнээс Бурханаар шүүгдсэн нь дээр, учир нь Бурханы шүүлтүүд үргэлж шударга, харин хүний шүүлтүүд үргэлж шударга байдаггүй.

13 Тиймийн тул, хэрэв та нар Бурханы хуулиудыг тогтоож, мөн энэ хүмүүсийг түүний зарлигуудын дагуу шүүх “шударга хүмүүсийг хаанаа болгож чадах нь боломжтой байсан аваас, тийм ээ, хэрэв та нар бүр миний эцэг ⁶Бенжамин энэ хүмүүсийн төлөө хийсний адилаар

хийх хүмүүсийг хаадаа болгож чадах юм бол—Би та нарт хэлнэ, хэрэв энэ нь үргэлж ийм байдалд байж чаддаг сан бол та нар өөрсдийн дээр захирах хааныг үргэлж байлгах нь зүйд нийцэх бөлгөө.

14 Мөн та нарт Бурханы зарлигуудыг сургахаар, мөн дайн бас зөрчилдөөн, хулгай, дээрэм, аллага, бас аливаа алдсуудыг байлгахгүйн тулд уг нутаг даяар амар амгаланг тогтоохоор би өөрөө хүртэл эзэмшиж буй бүх хүч мөн чадлаараа хөдөлмөрлөсөөр ирсэн бөлгөө;

15 Мөн алдсыг үйлдсэн хэнийг боловч, түүнийг бас түүний үйлдсэн гэмт хэргийнх нь дагуу, эцэг өвгөдөөр маань бидэнд өгөгдсөн хуулийн дагуу би “шийтгэж ирсэн билээ.

16 Эдүгээ би та нарт хэлнэ, хүн бүхэн шударга биш учраас та нар хаан эсвээс хаадыг өөрсдийн дээр захируулах нь зохистой бус бөлгөө.

17 Учир нь болгоогтун, нэгэн “ёс бус хаан ямар их алдсыг, тийм ээ, мөн ямар агуу их устгалыг үйлдүүлэх билээ!

18 Тийм ээ, хаан Ноаг, түүний “ёс бус үйлүүд хийгээд түүний жигшүүрт хэргүүдийг, мөн түүнчлэн түүний хүмүүсийн ёс бус үйлүүд хийгээд жигшүүрт хэргүүдийг санагтун. Ямар аймшигт устгал

тэдэн дээр ирснийг болгоогтун; мөн түүнчлэн алдсуудынхаа учир ^ббоолчлолд оруулагдсан бөлгөө тэд.

19 Мөн бүхнээс мэргэн тэдний Бүтээгч оролцоогүй аваас мөн тэдний чин сэтгэлийн наманчлалын учир бус аваас, одоог хүртэл тэд гарцаагүй боолчлолд үлдэх ёстой байсан билээ.

20 Гэвч болгоогтун, тэд өөрсдийгөө түүний өмнө “даруусгасны учир тэднийг тэрээр чөлөөлсөн юм; мөн тэд түүнд хүчтэйгээр ^бгуйж залбирсан учир тэрээр тэднийг боолчлолоос чөлөөлсөн юм; мөн “найдлагаа түүнд тавих тэдний зүг Их Эзэн “нигүүлслийн мутраа сунгаж хүмүүний үрсийн дунд бүх нөхцөлд ийн ажилладаг.

21 Мөн болгоогтун, эдүгээ би та нарт хэлнэ, та нар алдсыг үйлдэгч хааныг их тэмцэл, мөн их цус урсгалтгүйгээр буулгаж чадахгүй.

22 Учир нь болгоогтун, алдастаа тэрээр өөрийн “найзуудтай, мөн өөрийгөө хүрээлүүлэн харуулуудыг байлгадаг; мөн түүний өмнө зөв шударгаар засаглаж байсан тэдний хуулийг тэр урж тасчсан; мөн Бурханы зарлигуудыг тэр хөл дороо дэвсэлдэг.

23 Мөн тэр хуулиудыг тийм ээ, түүний өөрийнх нь “ёсон бусын дагуух хуулиудыг

15a Алма 1:32–33.

17a Алма 46:9–10;
Мозая 23:7–9.

18a Мозая 11:1–15.

б 1 Сам. 8:10–18;
Мозая 12:1–8;

Ифер 6:22–23.

20a Мозая 21:13–15.

б Ег. 2:23–25;

Алма 43:49–50.

в су Итгэл.

г Езек. 33:11, 15–16;

Мозая 26:30.

22a Хаад. дээд 12:8–14.

23a су Ёс бус, Ёс бус

явдал.

тогтоож, мөн тэдгээрийг хүмүүсийнхээ дунд илгээдэг; мөн түүний хуулиудыг дагаагүй хэнийг боловч тэр устгагдахаар болгоно; мөн түүний эсрэг тэмцсэн хэнд боловч их цэргээ тэдний эсрэг байлдуулахаар тэрээр илгээж, мөн хэрэв тэр чадвал тэднийг устгах болно; мөн тийн зөв шударга бус нэгэн хаан бүх зөв шударгын замуудыг гажуудуулдаг буюу.

24 Мөн эдүгээ болгоогтун би та нарт хэлнэ, та нарын дээр ийм жигшүүрт хэргүүд ирэх нь зүйд нийцэхгүй бөлгөө.

25 Тиймийн тул, зөв болох, мөн Их Эзэний мутраар тэдэнд өгөгдсөн, мөн эцэг өвгөдөөр маань бидэнд өгөгдсөн хуулиудын дагуу та нар шүүгдэж болохын тулд та нар энэ хүмүүсийн саналаар шүүгчдийг сонгогтун.

26 Эдүгээ хүмүүсийн санал зөв зүйлийн эсрэгийг хүсэх нь нийтлэг биш байдаг; харин хүмүүсийн цөөнх хэсэг нь зөв бус зүйлийг хүсэх нь элбэг; тиймийн тул үүнийг та нар даган мөн үүнийг — ажил хэргээ хүмүүсийн саналаар хийхийг хуулиа болгох болно.

27 Мөн “хэрэв хүмүүсийн санал алдсыг сонгох цаг ирвэл, Бурханы шүүлтүүд та нарын дээр ирэх цаг нь тэр болой; тийм ээ, тэрээр бүр үүнээс урьд энэ нутагт зочилсны адил аймшигт устгалаар та

нарын дээр зочлох цаг нь тэр болно.

28 Мөн эдүгээ хэрэв та нарт шүүгчид байвал, мөн тэд та нарыг өгөгдсөн тэр хуулийн дагуу шүүхгүй бол, та нар тэднийг илүү дээд шүүгчээр шүүлгэхээр болгож чадна.

29 Хэрэв танай илүү дээд шүүгчид зөв шударга шүүлтүүдээр шүүхгүй бол, та нар цөөн тооны доод шүүгчдийг нэгтгэн цуглуулж, мөн тэд танай дээд шүүгчдийг хүмүүсийн саналын дагуу шүүх болно.

30 Мөн Их Эзэнээс эмээх айдсандаа эдгээр зүйлийг хийхийг би та нарт зарлиг болгоно; мөн эдгээр зүйлийг хий мөн та нар хаангүй байхэмээн би та нарт зарлиг болно; хэрэв эдгээр хүмүүс нүгэл болоод алдсуудыг үйлдвэл тэдгээр нь өөрсдийнх нь толгой дээр хариулагдах болно.

31 Учир нь болгоогтун би та нарт хэлнэ, олон хүмүүний нүглүүд тэдний хаадын алдсаас болсон байдаг; тиймийн тул тэдний алдсууд хаадынх нь толгой дээр хариулагддаг.

32 Мөн эдүгээ энэ “тэгш бус байдал энэ нутагт, ялангуяа энэ миний хүмүүсийн дунд дахин бүү байгаасай хэмээн хүснэ би; харин энэ нутаг “эрх чөлөөний нутаг байж, мөн “хүн бүр өөрийн эрх мөн адил боломжуудыг адилхан эдлээсэй хэмээн хүснэ би, бид амьдарч мөн уг нутгийг өвлөж

27a Алма 10:19.

32a Алма 30:11.

б 2 Ниф. 1:7; 10:11.

су Эрх чөлөө.

в Алма 27:9.

болох нь хэдий хэр хугацаанд зохистой хэмээн Их Эзэн үзнэ, тийм ээ, бүр бидний үр удмын аливаа үлдэгдлүүд уг нутгийн гадаргуу дээр оршин байх тэр хугацааны турш буюу.

33 Мөн шударга хааны бүх сорилт мөн бэрхшээлүүдийг тэдэнд дэлгэн, мөн илүү олон зүйлийг, тийм ээ, хүмүүсийнхээ төлөө гэх бүх сэтгэлийн зовлонг, мөн түүнчлэн хаандаа хандсан хүмүүсийн бүх гомдлуудыг хаан Мозая тэдэнд бичив; мөн тэр энэ бүгдийг тэдэнд тайлбарлав.

34 Мөн эдгээр зүйлүүд байх нь зохистой бус; харин хүн бүр өөрийн хувийг үүрч болохын тулд ачаа нь бүх хүмүүсийн дээр ирвэл зохихыг тэрээр тэдэнд ярив.

35 Мөн түүнчлэн тэрээр зөв шударга биш хаан тэдний дээр хаанчилж байхад, тэдний харах бүх дутагдалтай талуудыг тэдэнд дэлгэн үзүүлэв.

36 Тийм ээ, түүний бүх алдсууд хийгээд жигшүүрт хэргүүд, мөн бүх дайнууд, мөн тэмцлүүд, мөн цус урсалт, бас хулгай, мөн дээрэм, түүнчлэн садар самууныг үйлдэх, мөн тоолж нэрлэгдэх боломжгүй бүх төрлийн алдсууд — тэдгээр нь Бурханы зарлигуудад илт харш учир тэдгээр зүйлүүд байх ёсгүйг тэдэнд хэлж өгөв.

37 Мөн эдүгээ улиран тохиох дор, хаан Мозая эдгээр зүй-

лийг хүмүүсийн дунд илгээсний дараа тэд түүний үгсийн үнэнд үнэмшив.

38 Тиймийн тул тэд хаантай байх хүслээсээ татгалзаж, мөн бүх нутаг даяар хүн бүр адил тэгш эрхтэй байхад үлэмж догдолж байв; тийм ээ, мөн хүн бүр нүглүүдээ хариуцахад бэлэн буйгаа илэрхийлэв.

39 Тиймийн тул, улиран тохиох дор тэдэнд өгөгдсөн “хуулийн дагуу тэднийг шүүх шүүгчид хэн байх талаар саналаа өгөхөөр тэд нутаг даяар хэсгүүдэд нэгдэн цугларав; мөн тэд өөрсдөд нь соёрхогдсон “эрх чөлөөний учир үлэмж баясав.

40 Мөн Мозаяд хандсан тэдний хайр нь хүчтэй болсон ажгуу; тийм ээ, өөр бусад ямар ч хүнээс илүү хүндэлсэн аж; учир нь хөрөнгийг, тийм ээ, сүнсийг ялзраах тэрхүү эд баялгийг эрэлхийлэгч дарлагчийн адил тэд түүнийг эс үзжээ; учир нь тэрээр баялгийг тэднээс шаардсангүй, бас цус урсахад ч баяссан нь үгүй; харин уг нутагт “амар амгаланг тэр тогтоож, мөн тэд бүх төрлийн боолчлолоос чөлөөлөгдөх нь шаардлагатайг тэрээр хүмүүстээ зөвшөөрчээ; тиймийн тул тэд түүнийг, тийм ээ, үлэмж, хэмжээлшгүй ихээр хүндэтгэж.

41 Мөнхүү улиран тохиох дор тэдний дээр захирах, эсвээс тэднийг хуулийн дагуу шүүх “шүүгчдийг тэд томил-

сон болой; мөн тэд үүнийг бүх нутаг даяар хийв.

42 Мөнхүү улиран тохиох дор Алма тэргүүн ерөнхий шүүгч байхаар томилогдов, мөн тэрээр түүнчлэн дээд санваартан байсан учир, эцэг нь түүний дээр алба тохоов, мөн сүмийн бүх хэргүүдийн талаарх хариуцлагыг түүнд өгсний учир бөлгөө.

43 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма Их Эзэний замуудаар “алхаж, мөн тэрээр түүний зарлигуудыг дагаж, мөн зөв шударга шүүлтүүдээр тэр шүүсэн болой; мөн уг нутаг даяар үргэлжийн амгалан байв.

44 Мөн тийн Зарахемлагийн бүх нутаг даяар, нифайчууд гэж нэрлэгдсэн бүх хүмүү-

сийн дунд шүүгчдийн засаглал эхлэв; мөн Алма тэргүүн мөн ерөнхий шүүгч байв.

45 Мөн эдүгээ улиран тохиох дор наян хоёр настай байхдаа, мөн Бурханы зарлигуудыг гүйцэлдүүлэхээр амьдарч асан түүний эцэг насан эцэслэв.

46 Мөнхүү улиран тохиох дор түүнчлэн Мозая засаглалынхаа гучин гурав дахь жилд, “жаран гурван настайдаа насан эцэслэв; мөн тэгэхээр Лихай Иерусалимыг орхисон цагаас хойш нийтдээ таван зуун есөн жил болжээ.

47 Мөн Нифайн хүмүүсийн дээрх хаадын засаглал ийн төгсөв; мөн тэдний сүмийг үндэслэгч асан, Алмагийн өдрүүд тийн төгсөв.

АЛМАГИЙН НОМ

АЛМАГИЙН ХҮҮ АСАН

Алмагийн хүү асан, Нифайн хүмүүсийн дээрх тэргүүн мөн ерөнхий шүүгч, мөн түүнчлэн Сүмийн дээрх дээд санваартан асан, Алмагийн шастир оршвой. Шүүгчдийн засаглал, мөн хүмүүсийн хоорондох дайнууд хийгээд зөрчлүүдийн талаарх шастир оршвой. Мөн түүнчлэн тэргүүн мөн ерөнхий шүүгч Алмагийн цэдгийн дагуу нифайчууд хийгээд леменчүүдийн дундах дайны шастир оршвой.

БҮЛЭГ 1

Нихор хуурамч сургаал зааж, сүм байгуулан, санваараар мэргэшихийг танилцуулж, мөн

Гидеоныг алав—Нихор гэмт хэргүүдийнхээ учир цаазлагдав—Санваараар мэргэших хийгээд хавчлагууд хүмүүсийн дунд тархав—Санваартнууд өөрс-

дийн хүчээр амьдарч, хүмүүс ядуусыг халамжилж, мөн Сүм хөгжив. Ойролцоогоор мээ 91–88.

ЭДҮГЭЭ улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын эхний жил, хаан Мозая амьдралыг зөвөөр залж, Бурханы өмнө зөв шударгаар алхлан, өөрийн оронд засаглах хэнийг ч үлдээлгүйгээр бүх хорвоогийн “жамаар одов; гэсэн хэдий ч тэрээр хуулиудыг тогтоож, тэдгээр нь хүмүүсээр хүлээн зөвшөөрөгдсөн байв; тиймийн тул, энэ цагаас эхлэн, тэд түүний тогтоосон ⁶хуулиудаар амьдрахаар албадуулсан байв.

2 Мөнхүү улиран тохиох дор Алмагийн шүүлтийн суудал дахь засаглалын эхний жилд, нэгэн “хүн шүүгдэхээр түүний өмнө авчрагдсан нь, том биетэй, их хүчтэйгээрээ нэрд гарсан нэгэн бөлгөө.

3 Мөн тэрээр хүмүүсийн дунд явж, тэрээр Бурханы үг хэмээн “нэрлэсэн зүйлээ тэдэнд номлон, сүмийн ⁶эсрэг тэмцэв; санваартан мөн багш бүр ⁶нэр хүндтэй болохыг; мөн тэд өөрсдийн гараар ‘хөдөлмөрлөхгүй байвал зохихыг, харин тэд хүмүүсээр тэтгэгдэх ёстойг хүмүүст тунхагладаг байв.

4 Мөн эцсийн өдөр бүх хүн төрөлхтөн аврагдах болно, мөн тэд айх бас чичрэх ч

хэрэггүй, харин тэд тэргүүнээ өргөн мөн баясаж болох ажээ; учир нь Их Эзэн бүх хүмүүнийг бүтээсэн, мөн түүнчлэн бүх хүмүүнийг гэтэлгэсэн; мөн, төгсгөлд нь, бүх хүмүүн мөнх амьдралтай байна хэмээн тэрээр хүмүүст түүнчлэн гэрчлэв.

5 Мөнхүү улиран тохиох дор олон нь түүний үгсэд итгэхээр тийм ихээр тэр эдгээр зүйлийг заасан аж, бүр тэд түүнийг дэмжиж мөн түүнд мөнгө өгч эхэлсэн нь тийм олон байсан бөлгөө.

6 Мөн тэрээр зүрхнийхээ бардамналд хөөрч эхлэв, мөн маш үнэтэй хувцас хунар өмсөж, тийм ээ, мөн өөрийн номлолын дагуу бүр “сүм байгуулж эхэлсэн билээ.

7 Мөнхүү улиран тохиох дор тэр өөрийнх нь үгэнд итгэсэн тэдэнд номлохоор явж байхдаа, тэр Бурханы сүмд хамаарагдах нэгэн хүнтэй, тийм ээ, бүр тэдний багш нарын нэгтэй нь тааралдав; мөн сүмийн хүмүүсийг тэрбээр зайцуулан удирдаж болохын тулд тэр түүнтэй хурцаар маргалдаж эхлэв; гэвч уг хүн Бурханы “үгсээр түүнийг зэмлэн түүнийг эсэргүүцэв.

8 Эдүгээ сайхь хүний нэр “Гидеон байв; мөн Лимхайн хүмүүсийг дарангуйллаас чөлөөлөхөд Бурханы мутарт зэмсэг байсан тэр байв.

[АЛМА]

1 *1a* Мозая 29:46.

б Жером 1:5;

Алма 4:16;

Хил. 4:22.

2*a* Алма 1:15.

3*a* Езек. 13:3.

б су Христийн эсрэг.

в Лук 6:26;

1 Ниф. 22:23.

г Мозая 18:24, 26; 27:5.

6*a* 1 Ниф. 14:10.

7*a* су Бурханы Үг.

8*a* Мозая 20:17; 22:3.

9 Эдүгээ, Бурханы үгсээр Гидеон түүнийг сөрөн зогссон учир тэр Гидеонд хилэгнэж, мөн илдээ сугалаад түүнийг дайрч эхлэв. Эдүгээ Гидеон олон жил насалсан байв, тиймийн тул тэрээр түүний дайралтуудыг эсэргүүцэн зогсох чадалгүй байлаа, тиймийн тул тэрээр илдэнд “хөнөөгдөв.

10 Мөн түүнийг хөнөөсөн хүн сүмийн хүмүүсээр баривчлагдаж, мөн тэр үйлдсэн гэмт хэргүүдийнхээ дагуу “шүүгдэхээр Алмагийн өмнө авчрагдав.

11 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Алмагийн өмнө зогсож мөн ихэд зоригтойгоор өөрийгөө өмгөөлөв.

12 Харин Алма түүнд хэлэв: Болгоогтун, “санваараар мэргэших нь хүмүүсийн дунд анх удаа танилцуулагдсан нь энэ юм. Мөн болгоогтун, та зөвхөн санваараар мэргэшсэний ч гэмтэй биш, бас үүнийг илдээр албадахыг оролдсон байна; мөн санваараар мэргэших нь энэ хүмүүсийн дунд албаар тулгагдваас энэ нь тэдний бүрэн устгалын шалтгаан болох сон.

13 Мөн та зөв шударга хүний цусыг, тийм ээ, энэ хүмүүсийн дунд ихээхэн сайныг хийсэн тэр хүнийхийг урсгалаа; мөн бид таныг хэлтрүүлэх аваас түүний цус “өшөө

хонзонгийн учир бидэн дээр ирэх болно.

14 Тиймийн тул та, бидний сүүлчийн хаан, Мозаягаар бидэнд өгөгдсөн тэр хуулийн дагуу үхэхээр яллагдлаа; мөн энэ нь хүмүүсээр хүлээн зөвшөөрөгдсөн бөлгөө; тиймийн тул энэ хүмүүс уг хуулийг “мөрдөх ёстой.

15 Мөнхүү улиран тохиох дор тэд түүнийг баривчлав; мөн түүний нэр “Нихор байв; мөн тэд түүнийг Мантай толгойн орой дээр аваачиж, тэнгэр газрын савслаганд хүмүүст түүний заасан нь Бурханы үгний эсрэг байсан гэдгээ тэрээр хүлээн зөвшөөрөв, эсвээс өөрөөр хэлбэл, мөн тэнд тэр албадуулагдав; мөн тэнд тэрээр ичгүүрт ^бүхлийг үзэв.

16 Гэсэн хэдий ч, энэ нь санваараар мэргэшихийг уг нутаг даяар тархахыг төгсгөл болгосонгүй; учир нь дэлхийн хоосон чанарын зүйлүүдэд дуртай болсон нь олон байв, мөн тэд хуурамч сургаалуудыг номлон явж байв; мөн тэд үүнийг “баялаг болоод алдрын төлөө хийсэн бөлгөө.

17 Гэсэн хэдий ч, тэд мэдэгдэхээр “худал хэлж зүрхэлсэнгүй, худалчид шийтгэгдэж байсан тул хуулийн учир айсан аж; тиймийн тул тэд сүсэг бишрэлийнхээ дагуу номлож буй дүр үзүүлж байв;

9a Алма 6:7.
10a Мозая 29:42.
12a 2 Ниф. 26:29.
су Санваараар
мэргэших.

13a су Өс хонзон.
14a су Ухлийн шийтгэл.
15a Алма 1:2.
б Дэд хууль 13:1–9.
16a су Баялгууд;

Хоосон үг, Хоосон
үг ярих.
17a су Үнэнч, Үнэнч
шударга; Худал
хэлэх.

мөн эдүгээ уг хууль нь ^бсүсэг бишрэлийн хувьд ямар ч хүний дээр хүчгүй байв.

18 Мөн тэд хуулиас айх учир “хулгайлж зүрхэлсэнгүй, тийм нь шийтгэгдэж байсны учир бөлгөө; бас тэд дээрэм, мөн ^баллага хийж зүрхэлсэнгүй, учир нь аллага хийсэн нь “үхлээр шийтгэгдэж байлаа.

19 Гэвч улиран тохиох дор Бурханы сүмд хамаарагдаагүй хэн боловч Бурханы сүмд харьяалагдаж, Христийн нэрийг өөрсдийн дээр авсан тэднийг хавчин гадуурхаж эхлэв.

20 Тийм ээ, тэд тэднийг хавчин гадуурхаж, мөн тэднийг янз бүрийн үгсээр зовоож байв, мөн энэ нь тэдний даруу төлвийн учир бөлгөө; учир нь тэд өөрсдийн нүдэнд бардам байсангүй, мөн тэд Бурханы үгийг нэг нэгэнтэйгээ, “мөнгөгүйгээр мөн үнэгүйгээр хуваалцдаг байсны учир бөлгөө.

21 Эдүгээ сүмийн хүмүүсийн дунд, сүмд харьяалагдсан нэг ч хүн сүмд харьяалагдаагүй тэдний эсрэг босч мөн “хавчин гадуурхаж болохгүй, мөн тэдний өөрсдийнх нь дунд ч хавчлага байх ёсгүй хэмээх хатуу хууль байв.

22 Гэсэн хэдий ч, тэдний дунд бардам болж эхэлсэн нь, мөн өрсөлдөгчидтэйгээ ширүүн, бүр зодолдох хүртлээ

тэмцэлдэж эхэлсэн нь олон байв; тийм ээ, тэд бие биенээ нударгалан жанчих болов.

23 Эдүгээ энэ нь Алмагийн засаглалын хоёр дахь жилд, мөн энэ нь сүмд их зүдгүүрийн шалтгаан байв; тийм ээ, энэ нь сүмд их бэрхшээлийн шалтгаан байв.

24 Учир нь олны зүрх сэтгэл хатуурч, мөн Бурханы хүмүүсийн дунд тэд дахин дурсагдахгүйн тулд тэдний нэрс “арилгагдав. Мөн түүнчлэн олон нь тэдний дундаас өөрсдийгөө ^бхолдуулав.

25 Эдүгээ энэ нь сүсэг бишрэлдээ үнэнч үлдсэн тэдэнд агуу бэрхшээл болов; гэсэн хэдий ч, тэд Бурханы зарлигуудыг дагахдаа хөдөлшгүй мөн гуйвшгүй байв, мөн тэд өөрсдийн дээр овоологдсон хавчлага гадуурхлыг “тэвчээртэйгээр үүрч байв.

26 Мөн санваартнууд Бурханы үгийг хүмүүстэй хуваалцахаар “хөдөлмөрөө орхиход, хүмүүс ч түүнчлэн Бурханы үгийг сонсохоор хөдөлмөрлөхөө орхиж байв. Мөн санваартан тэдэнд Бурханы үгийг дуулгамагц тэд бүгд хөдөлмөртөө дахин хичээнгүйлэн орж байв; мөн санваартан нь, өөрийгөө сонсогчдоосоо дээр хэмээн үнэлэхээ болсон аж, учир нь номлогч нь сонсогчоосоо өчүүхэн ч илүү

17б Алма 30:7–12;
ИТ 1:11.

18а су Хулгай хийх,
Хулгай.

б су Аллага.

в су Үхлийн шийтгэл.

20а Иса. 55:1–2.

21а су Хавчих, Хавчлага.

24а Ег. 32:33;

Мозая 26:36;

Алма 6:3.

су Сүмээс хөөх.

б Алма 46:7.

су Урвалт.

25а су Тэвчээр.

26а Мозая 18:24, 26;

27:3–5.

бус ажгуу, бас багш нь сурагчаасаа илүү бус бөлгөө; мөн тийн тэд бүгд адил тэгш, мөн тэд бүгд, хүн бүр өөрт буй ⁶хүчнийхээ дагуу хөдөлмөрлөж байв.

27 Мөн тэд хөрөнгөнөөсөө, хүн бүр өөрт байгаагийнхаа хэрээр, “ядуутай, мөн гачигдсантай, мөн өвдсөнтэй мөн зовж зүдэрсэнтэй ⁶хуваалцаж байлаа; мөн тэд үнэтэй хувцас хунар өмсдөггүй байв, гэвч тэд цэвэр нямбай мөн дур булаам байсан буюу.

28 Мөн тийн тэд сүмийн хэргүүдийг тогтоов; мөн тийн тэдний бүх хавчлагууд байсан хэдий ч тэд үргэлжийн амгаланг дахин эдэлж эхлэв.

29 Мөн эдүгээ, сүмийн чанд байдлын учир тэд үлэмж “баян болж эхлэн, тэдэнд хэрэгцээтэй аливаа бүх зүйлээр—үй түмэн бог мөн бод мал, мөн зүйл бүрийн төл мал, мөн түүнчлэн арвин их үр тариа, мөн алт, мөн мөнгө, мөн үнэт зүйлүүд, мөн арвин их ⁶торго хийгээд нарийн нэхээст эд, мөн төрөл бүрийн энгийн сайн давуугаар элбэг хангалуун байх болов.

30 Мөн тийн, тэд “нүцгэрсэн, эсвэл өлссөн, эсвэл цангасан, эсвэл өвдсөн, эсвэл асаргаагүй байсан нэгнийг ч ⁶хангалуун байдалдаа тэд

буцаагаагүй болой; мөн тэд зүрх сэтгэлээ баялаг дээр тулгуурласангүй; тиймийн тул тэд, настай мөн залуу аль алинд нь, боол мөн чөлөөт аль алинд нь, эрэгтэй мөн эмэгтэй аль алинд нь, сүмийнх биш ч бай, мөн ч бай, чухам ямар хүмүүс байгаагаас нь “үл хамааран гачигдах тэднийг бүгдийг энэрч байв.

31 Мөн тийн тэд дэгжиж мөн сүмд нь харьяалагдаагүй тэднээс хамаагүй илүү чинээлэг болов.

32 Учир нь тэдний сүмд харьяалагдаагүй тэд илбэ шидэд, мөн “хиймэл шүтээнийг шүтэхэд эсвээс ⁶залхуу хойрго байдалд, мөн “чалчаа яриа, мөн ‘атаа жөтөө мөн хэрүүл маргаанд өөрсдийгөө өөгшүүлж байв; үнэтэй хувцас өмсөн; өөрсдийнхөө нүдэнд бардамнан ⁶хөөрч; бусдыг хавчин, худал хэлж, хулгайлж, дээрэмдэж, садар самууныг үйлдэн, мөн аллага, мөн зүйл бүрийн ёс бусыг үйлдэж байв; гэсэн хэдий ч, үүнийг зөрчсөн тэд бүгдийн дээр уг хууль боломжийн хэрээр хэрэгжүүлэгдэж байв.

33 Мөнхүү улиран тохиох дор хүн бүр өөрийн хийсэн зүйлийхээ дагуу шийтгэгдэн, тэдний дээр хуулийг хэрэгжүүлснээр, тэд илүү тайван

266 Мозая 4:27;
С ба Г 10:4.

27a Лук 18:22;
Мозая 4:26;
С ба Г 42:29–31.
б Өглөг, Өглөг
сүгөх.

29a су Баялгууд.

б Алма 4:6.
30a Иаков 2:17–19.

б су Ядуус.
в Алма 16:14;
С ба Г 1:35.
32a су Хиймэл шүтээн.
б су Залхуурах,
Залхуу.

в су Хилэнцэтийг
ярих.

г су Атаархал.
д Иаков 2:13;
Алма 31:25;
Морм. 8:28.
су Бардамнал.

болж, мөн хэрэв мэдэгдэхээр бол ямар ч ёс бусыг үйлдэж зүрхлэхгүй байв; тиймийн тул, Нифайн хүмүүсийн дунд шүүгчдийн засаглалын тав дахь жилийг хүртэл туйлын их амар амгалан байв.

БҮЛЭГ 2

Амлисай хаан байхыг эрэлхийлж мөн хүмүүсийн саналаар эсэргүүцэгдэв—Түүний дагалдагчид түүнийг хаан болгов—Амлисайчууд нифайчуудтай дайтаж мөн ялагдав—Леменчүүд мөн амлисайчууд хүчээ нэгтгэн мөн ялагдав—Алма Амлисайг хөнөөв. Ойролцоогоор мээ 87 он.

Мөнхүү улиран тохиох дор тэдний засаглалын тав дахь жилийн эхэнд хүмүүсийн дунд нэгэн зөрчилдөөн гарч эхлэв; учир нь, Амлисай гэж нэрлэгдсэн нэгэн хүн, тэрээр машинд зальжин эр байж, тийм ээ, энэ дэлхийн мэргэн ухааны хувьд ухаалаг хүн буюу, тэр “Гидеоныг илдээр алж, хуульд заасны дагуу цаазлагдсан хүний жаягийн дагуу байв—

2 Эдүгээ сайхь Амлисай заль мэхээрээ тийм олон хүнийг, бүр тэд ихэд хүчтэй болж эхэлсэн; олон хүнийг өөрийн араас дагуулав; мөн тэд Амлисайг уг хүмүүсийг захирах хаан болгохыг оролдож эхлэв.

3 Эдүгээ энэ нь сүмийн хүмүүсийг, мөн түүнчлэн

Амлисайн ятгалганд автаагүй тэдгээр бүх хүмүүсийг цочирдуулав; учир нь ийм зүйлүүд тэдний хуулийн дагуу хүмүүсийн “саналаар тогтоогдох ёстойг тэд мэдэж байв.

4 Тиймийн тул, хэрэв Амлисай хүмүүсийн саналыг авах нь боломжтой байсан бол, тэрээр, ёс бус хүмүүн байсан учир, сүмийнх нь эрх хийгээд боломжуудыг тэднээс “булааж авах буйза; учир нь Бурханы сүмийг устгах нь түүний санаа байв.

5 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс бүх нутаг даяар, Амлисайг дэмжсэн эсэргүүцсэн алин боловч хүн бүр өөрийн бодлын дагуу тус тусдаа цуглан чуулж, мөн тэд нэг нэгэнтэйгээ ширүүн маргаан болон их “зөрчилдөөнтэй байв.

6 Мөн тийн уг хэргийн талаар саналаа өгөхөөр тэд өөрсдөө нэгдэн цугларцгаав; мөн тэдгээр нь шүүгчдийн өмнө толилуулагдав.

7 Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн санал Амлисайн эсрэг ирсэн учир тэрээр хүмүүсийн дээрх хаанаар тохоогдсонгүй.

8 Эдүгээ энэ нь түүний эсрэг байсан тэдний зүрх сэтгэлд маш их баяр хөөр авчрав; харин Амлисай өөрийнх нь талд байсан тэднийг түүний талд байгаагүй тэдний эсрэг уурлуулахаар өдөөн хатгав.

9 Мөнхүү улиран тохиох дор тэд өөрсдөө цугларцгааж,

мөн Амлисайг хаанаа болгохоор томилон адислав.

10 Эдүгээ Амлисай тэдний дээрх хаанаар тохоогдмогцоо тэрээр тэднийг ах дүүсийнхээ эсрэг зэвсгээ агсахыг тэдэнд зарлиглав; мөн тэрээр тэднийг өөртөө харьяалуулж болохын тулд үүнийг хийсэн болой.

11 Эдүгээ Амлисайн хүмүүс “амлисайчууд гэж нэрлэгдэн, Амлисайн нэрээр ялгагдах болов; мөн үлдсэн нь ^бнифайчууд буюу Бурханы хүмүүс хэмээн нэрлэгдэж асан бөлгөө.

12 Тиймийн тул Нифайн хүмүүс амлисайчуудын зорилтын талаар мэдэж байв, мөн тиймийн тул тэдэнтэй тулгарахаар тэд бэлтгэл хийв; тийм ээ, тэд өөрсдийгөө сэлэм, мөн илд, мөн нум, мөн сум, мөн чулуу, мөн дүүгүүр, мөн зүйл бүрийн “дайны зэвсгээр, төрөл бүрээр нь зэвсэглэв.

13 Мөн тэднийг ирэх үед нь амлисайчуудтай тулгарахаар тэд тийн бэлтгэсэн байв. Мөн ахлагчид, мөн дээд ахлагчид, мөн ерөнхий ахлагчид зохих тоогоороо томилогдсон байв.

14 Мөнхүү улиран тохиох дор Амлисай өөрийн эрчүүдийг олон зүйлийн төрөл бүрийн дайны зэвсгээр зэвсэглэв; мөн хүмүүсийнхээ дээр тэднийг ах дүүсийнх нь эсрэг дайнд удирдах захирагч мөн

толгойлогчдыг тэр түүнчлэн томилов.

15 Мөнхүү улиран тохиох дор амлисайчууд “Зарахемла нутгийн дэргэдүүр урсдаг, ^бСидон голын дорнод тэр Амнайху толгой дээр ирж, мөн тэнд тэд нифайчуудтай дайтаж эхлэв.

16 Эдүгээ Алма, Нифайн хүмүүсийн “ерөнхий шүүгч мөн засаглагч байв, тиймийн тул тэрээр өөрийн хүмүүстэй, тийм ээ, ахлагч нартайгаа, мөн ерөнхий ахлагч нартайгаа, тийм ээ, амлисайчуудын эсрэг дайтахаар их цэргийнхээ тэргүүнд явав.

17 Мөн тэд Сидоны зүүн талын толгой дээр амлисайчуудыг хөнөөж эхлэв. Мөн амлисайчууд агуу хүчээр нифайчуудтай тэмцэж, үүний хэрээр нифайчуудын олон нь амлисайчуудын өмнө унасан болой.

18 Гэсэн хэдий ч нифайчуудын гарыг Их Эзэн хүчирхэгжүүлснээр тэд их хөнөөлөөр амлисайчуудыг хөнөөж, тэдний өмнө тэд зугтаж эхэлсэн болой.

19 Мөнхүү улиран тохиох дор нифайчууд бүхэл өдөр амлисайчуудыг мөшгөн, мөн их хөнөөлөөр тэднийг хөнөөв, үүний хэрээр амлисайчуудаас арванхоёр мянга таван зуун гучин хоёр бодгаль “алагдав; мөн нифайчуудын зургаан мянга таван зуун

11а Алма 3:4.
б Иаков 1:13–14;
Мозая 25:12;
Алма 3:11.

12а Мозая 10:8;
Хил. 1:14.
15а Омнай 1:13–15.
б Алма 3:3.

16а Мозая 29:42.
19а Алма 3:1–2, 26; 4:2.

жаран хоёр бодгаль алагдсан байв.

20 Мөнхүү улиран тохиох дор амлисайчуудыг дахин цааш мөшгөх боломжгүй болоод Алма өөрийн хүмүүсийг “Нихорын гараар илдэнд алагдсан Гидеоны нэрээр нэрлэгдсэн нэгэн хөндий, ⁶Гидеоны хөндийд майхнуудаа босгохоор болгов; мөн энэ хөндийд нифайчууд шөнө хоноглохоор майхнуудаа босгосон ажээ.

21 Мөн тэгснээр өөрийгөө тэднээс хамгаалж болохын тулд, өөрийн хүмүүсийг устгагдахаас хамгаалан үлдэж болохын тулд, тэдний төлөвлөгөөнүүд хийгээд тэдний санааг мэдэхийн тулд амлисайчуудын үлдэгдлийг дагах туршуулуудыг Алма илгээв.

22 Эдүгээ амлисайчуудын буудлыг ажиглахаар түүний гадагш илгээсэн тэднийг Зерам, Амнор, Мантай, Лимхер гэж нэрлэдэг байв; эдгээр нь амлисайчуудын буудлыг харахаар эрчүүдтэйгээ явсан тэд байв.

23 Мөнхүү улиран тохиох дор маргааш нь тэд ихэд гайхан цочирдон, мөн үлэмж айснаас балмагдан, нифайчуудын буудалд ихэд яаравчлан тэд эргэж ирээд, хэлрүүн:

24 Болгоогтун, бид “амлисайчуудын буудлыг дагалаа, мөн бидний гайхлыг ихэд төрүүлсэн нь юув гэвэл, Зарахемла нутгийн дээрх Минон нутагт,

⁶Нифайн нутагт очих замд, бид леменчүүдийн олон тооны их цэргийг харлаа; мөн болгоогтун, амлисайчууд тэдэнтэй нэгдсэн бөлгөө;

25 Мөн тэд уг нутаг дахь ах дүүсийн маань дээр байна, мөн тэд мал сүрэг, мөн эхнэр, мөн хүүхдүүдтэйгээ манай хотын зүг тэдний өмнө зугтаж явна; мөн хэрэв бид яарахгүй аваас тэд хотыг маань эзэмшилдээ авч, мөн бидний эцэг, мөн эхнэрүүд маань, мөн хүүхдүүд маань алагдах болно.

26 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүс майхнуудаа авч, мөн Гидеоны хөндийгөөс гарч “Зарахемлагийн хот болох тэр хотынхоо зүг одов.

27 Мөн болгоогтун, тэднийг Сидоны голыг гаталж байх зуур, тоо тоолшгүй олон леменчүүд болоод амлисайчууд, тэнгисийн элсний ширхэг мэт “олноор, тэднийг устгахаар тэдний дээр ирэв.

28 Гэсэн хэдий ч, нифайчууд Их Эзэний мутраар “хүчирхэгжиж, тэрээр тэднийг дайснуудынх нь гараас чөлөөлөөсэй хэмээн түүнд хүчтэйгээр залбирч байв, тиймийн тул Их Эзэн тэдний гуйлтыг сонсож, мөн тэднийг хүчирхэгжүүлэн, мөн леменчүүд болон амлисайчууд тэдний өмнө унасан болой.

29 Мөнхүү улиран тохиох дор Алма илдээр Амлисайтай халз тулалдав; мөн тэд өөр

20a Алма 1:7–15; 14:16.

б Алма 6:7.

24a Алма 3:4, 13–18.

б 2 Ниф. 5:8.

26a Омнай 1:14, 18.

27a Жером 1:6.

28a Дэд хууль 31:6.

хоорондоо хүчтэйгээр тэмцэлдэв.

30 Мөнхүү улиран тохиох дор Алма, Бурханы хүн байж, их “итгэлээ бодит болгосон байсны учир, гуйж, хэлрүүн: Ай Их Эзэн, би таны мутарт зэмсэг байж энэ хүмүүсийг аварч мөн хамгаалан үлдэж болохын тулд нигүүлсэж мөн амийг минь хэлтрүүлээч.

31 Эдүгээ Алма эдгээр үгсийг хэлээд тэрээр Амлисайтай дахин тэмцэлдэв; мөн тэрээр хүчирхэгжсэн байв, үүний хэрээр тэр Амлисайг илдээр хөнөөв.

32 Мөн түүнчлэн тэр леменчүүдийн хаантай тулалдав; гэвч леменчүүдийн хаан Алмагаас ухран зугтаж мөн харуулуудаа Алматай тэмцэлдүүлэхээр илгээв.

33 Харин Алма, харуулуудынхаа хамт, тэднийг хөнөөж мөн буцаан ухраатал леменчүүдийн хааны харуулуудтай тэрээр тэмцэлдсэн бөлгөө.

34 Мөн тийн тэр уг газрыг өөрөөр хэлбэл Сидон голын баруунтаах эргийг түүний хүмүүс голыг гатлан мөн леменчүүд болон амлисайчуудтай Сидон голын баруун эрэг дээр тэмцэлдэж болохын тулд алагдсан леменчүүдийн цогцсыг Сидоны усанд хаяж цэвэрлэв.

35 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгд Сидон голыг гаталсны дараа леменчүүд хийгээд амлисайчууд тоологдсон байхын аргагүй тийм

олон тоотой байсан хэдий ч тэдний өмнө зугтаж эхлэв.

36 Мөн тэд баруун хойд зүгт, уг нутгийн хилийн чанад дахь аглаг буйдын зүг чиглэн нифайчуудын өмнө зугтав; мөн нифайчууд тэднийг чадлаараа мөшгөж, мөн тэднийг хөнөөв.

37 Тийм ээ, тэд өрнөдөд, мөн умардад тараагдах хүртлээ, тэд Хермаунтс гэж нэрлэгдсэн аглаг буйдад хүрэх хүртлээ, зүг бүрээсээ тэд тулгагдаж, мөн алуулж, туугдаж байв; мөн энэ нь зэрлэг хийгээд өлсгөлөн араатнуудаар эзлэгдсэн аглаг буйдын тэр хэсэг байсан болой.

38 Мөнхүү улиран тохиох дор тэдний олон нь шархнаасаа болж аглаг буйдад үхээд, мөн тэдгээр араатнууд мөн түүнчлэн тэнгэрт эргэлдэх тас шувуудад цөлмүүлсэн болой; мөн тэдний яс нь олдож, мөн газар овоологдсон байв.

БҮЛЭГ 3

Амлисайчууд өөрсөд дээрээ бошиглолын үгийн дагуу тэмдэг тавьсан байв—Леменчүүд эсэргүүцлийнхээ учир зүхэгдэв—Хүмүүн өөрсдийнхөө зүхлүүдийг өөрсөд дээрээ авчирдаг—Леменчүүдийн өөр нэг их цэргийг нифайчууд ялав. Ойролцоогоор мээ 87–86 он.

Мөнхүү улиран тохиох дор дайны зэвсэгт “хөнөөгдөөгүй тэдгээр нифайчууд, хө-

нөөгдсөн тэднийг оршуулсны дараа — эдүгээ алагдагсдын тоо тоологдсонгүй, учир нь тэдний тоо агуу олон байв — тэд өөрсдийн амь үрэгдэгсдийг оршуулж дууссаны дараа нутагтаа, мөн гэртээ, мөн эхнэрүүддээ, мөн хүүхдүүддээ бүгд эргэж очицгоов.

2 Эдүгээ олон эмэгтэйчүүд мөн хүүхдүүд, мөн түүнчлэн тэдний бог болон бод малаас олон нь илдэнд алагдсан байв; мөн түүнчлэн тэдний үр тарианы талбайгаас олон нь устгагдав, учир нь тэд олон хүмүүсийн хөл доор гишгэгдсэн байлаа.

3 Мөн эдүгээ Сидон “голын эрэг дээр алагдсан леменчүүд болон амлисайчууд бүгд Сидоны усанд хаягдав; мөн болгоогтун тэдний яс ^бтэнгисийн гүнд буй, мөн тэдгээр нь олон буй.

4 Мөн “амлисайчууд нифайчуудаас онцлогдов, учир нь тэд леменчүүдийн маягаар духан дээрээ улаанаар ^бтэмдэг тавьсан байв; гэсэн хэдий ч тэд леменчүүдийн адил толгойн үсээ хуссан нь үгүй.

5 Эдүгээ леменчүүд толгойн үсээ хуссан байв; мөн тэдний хэвлийн тус бүсэлсэн арьс, мөн түүнчлэн тэдний зүүсэн хуяг, мөн тэдний нумнууд, мөн тэдний сумнууд, мөн тэдний чулуунууд, мөн тэд-

ний дүүгүүрүүд гэхчлэнгээс бусдаар бол тэд “нүцгэн байв.

6 Мөн тэдний эсэргүүцэл хийгээд тэдний зөрчлийн учир тэдэнд ирсэн “зүхэл болох, тэдний эцэг өвгөдийн дээр тавигдсан тэмдгийн дагуу леменчүүдийн арьс бараан байв, шударга бөгөөд ариун хүмүүс асан Нифай, Иаков мөн Иосеф мөн Самаас бүрдсэн дүү нарынхаа эсрэг тэрхүү эсэргүүцэл мөн зөрчлийнх нь учир буюу.

7 Мөн ах нар нь тэднийг устгахыг эрэлхийлж, тиймийн тул тэд зүхэгдсэн бөлгөө; мөн Их Эзэн Бурхан тэдний дээр, тийм ээ, Лемен болон Лемүел, мөн түүнчлэн Ишмэилийн хөвгүүд, мөн Ишмэил үндэстний эмэгтэйчүүдийн дээр “тэмдэг тавьжээ.

8 Мөн энэ нь тэдний үр удам тэдний дүү нарынх нь үр удамаас ялгагдаж болохын тулд хийгдсэн ажгуу, тэгснээр Их Эзэн Бурхан өөрийн хүмүүсийг хадгалан үлдээж болно хэмээн, өөрсдийг нь устгалд хүргэх зөв бус “уламжлалуудад тэд ^бхолилдож мөн итгэхгүйн тулд буюу.

9 Мөнхүү улиран тохиох дор өөрийн үр удмыг леменчүүдийнхтэй холилдуулах хэн боловч үр удмынхаа дээр нэгэн адил зүхлийг авчирсан болой.

3а Алма 2:15.

б Алма 44:22.

4а Алма 2:11.

б Алма 3:13–19.

5а Инос 1:20;

Мозая 10:8;

Алма 42:18–21.

6а 2 Ниф. 5:21; 26:33.

су Хараах, Хараал.

7а 1 Ниф. 12:23.

8а Мозая 10:11–18;

Алма 9:16.

б су Гэрлэл, Гэрлэх—

Нэг адил итгэлтэй

хүмүүсийн

хоорондох гэрлэлт.

10 Тиймийн тул, өөрийгөө леменчүүдээр удирдуулахыг зөвшөөрсөн хэн боловч тэр овгийн дор нэрлэгдэж, мөн түүний дээр тэмдэг тавигдсан билээ.

11 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн “уламжлалд үл итгэн, харин Иерусалим нутгаас авчрагдсан тэдгээр цэдгүүдэд мөн түүнчлэн эцэг өвгөдийнхөө зөв болох тэрхүү уламжлалд итгэсэн, Бурханы зарлигуудад итгэж мөн тэдгээрийг дагасан хэн боловч, тэр цагаас хойш нифайчууд буюу Нифайн хүмүүс хэмээн нэрлэгдсэн бөлгөө —

12 Мөн өөрсдийн хүмүүсийн, мөн түүнчлэн леменчүүдийн ард түмний “үнэн болох тэрхүү цэдгүүдийг хадгалсан нь тэд болой.

13 Эдүгээ бид амлисайчуудын тухай сэдэвтээ эргэж орё, учир нь тэд түүнчлэн дээрээ “тэмдэгтэй байв; тийм ээ, тэд өөрсдийн дээр уг тэмдгийг, тийм ээ, бүр духан дээрээ улаан тэмдэг тавьсан аж.

14 Тийн Бурханы үг биелэгдсэн ажээ, учир нь Нифайд хэлсэн түүний үгс нь эдгээр болой: Болгоогтун, леменчүүдийг би зүхсэн, мөн тэд өөрсдийнхөө ёс бусыг наманчилж мөн тэдний дээр би нигүүлслийг үзүүлж болохын тул надад “хандахаас бусдаар бол, энэ цагаас хойш мөн үүрд, тэд болон тэдний үр удам чамаас мөн чиний үр удмаас

ялгагдаж болохын тулд тэдэн дээр би тэмдэг тавих болно.

15 Мөн үүнчлэн: Өөрийн үр удмыг ах дүүстэй чинь холилдуулах тэдний дээр, тэд түүнчлэн зүхэгдэж болохын тулд би тэмдэг тавих болно.

16 Мөн үүнчлэн: Би чиний мөн чиний үр удмын эсрэг тулалдах тэдэн дээр тэмдэг тавих болно.

17 Мөн үүнчлэн, чамаас салж одох тэрбээр чиний үр удам гэж дахин нэрлэгдэхгүйг би хэлнэ; мөн би чамайг, мөн чиний үр удам гэж нэрлэгдэх хэнийг боловч, цаашид мөн үүрд адислах болно; мөн эдгээр нь Нифай мөн түүний үр удамд өгсөн Их Эзэний амлалтууд байв.

18 Эдүгээ тэд духан дээрээ тэмдэг тавьж эхлэхдээ амлисайчууд тэд Бурханы үгийг биелүүлснээ мэдсэнгүй; гэсэн хэдий ч тэд Бурханы эсрэг илэрхий “эсэргүүцэлд гарч ирсэн байв; тиймийн тул зүхэл тэдний дээр унах нь зайлшгүй байсан бөлгөө.

19 Эдүгээ тэд өөрсдийнхөө дээр “зүхлийг авчирсныг та нар ойлгоосой хэмээнэ би; мөн тэрчлэн зүхэгдсэн хүн бүр өөрийн ялыг өөр дээрээ авчирдаг.

20 Эдүгээ улиран тохиох дор леменчүүд болон амлисайчуудаар Зарахемла нутагт өдөөгдсөн тэр тулаанаас тийм ч олон бус өдрийн дараа, анхны их цэрэг нь амлисай-

11a Алма 17:9–11.
12a Мозая 1:6;
Ифер 4:6–11.

13a Алма 3:4.
14a 2 Ниф. 30:4–6.
18a 4 Ниф. 1:38.

су Эсэргүүцэл.
19a 2 Ниф. 5:21–25;
Алма 17:15.

чуудын цэрэгтэй тулгарсан “мөнхүү тэр газар леменчүүдийн өөр нэг их цэрэг Нифайн хүмүүсийн дээр ирэв.

21 Мөнхүү улиран тохиох дор тэднийг нутгаасаа хөөж гаргахын тулд их цэрэг илгээгдэв.

22 Эдүгээ Алма “шархандаа шаналж байсан учир энэ удаа леменчүүдийн эсрэг тулалдаанд өөрөө явсангүй;

23 Гэвч тэр олон тооны их цэргийг тэдний эсрэг илгээв; мөн тэд өгсөн одож мөн леменчүүдээс олныг нь алж, мөн тэднээс үлдсэнийг нь нутгийнхаа хилээс үлдэн хөөв.

24 Мөн тэгээд тэд дахин эргэж ирээд мөн уг нутагт амар амгаланг тогтоож эхлэв, хэсэг хугацаагаар дайснууд нь дахин тэднийг түйвүүлээгүйн учир болой.

25 Эдүгээ эдгээр бүх зүйл хийгдэв, тийм ээ, эдгээр бүх дайн мөн тэмцлүүд шүүгчдийн засаглалын тав дахь онд эхэлж мөн төгсөв.

26 Мөн тэд сайн байсан эсэхээс эсвээс тэд муу байсан эсэхээс, өөрсдийн үйлүүдийн дагуу “шагналуудаа хадаж болохын тулд, сайн эсвээс муу сүнс байхаас хамааран, тэд дагахаар шийдсэн тэрхүү сүнснийхээ дагуу, мөнхийн аз жаргалыг, эсвээс мөнхийн зовлонг тэд хадан авахаар нэгэн жилд мянга мянган мөн

хэдэн арван мянган бодгаль мөнхийн оронд илгээгдэв.

27 Учир нь хүн бүр “дагахаар сонгосон түүнээсээ “шангаа хүлээж авдаг, мөн энэ нь бошиглолын суу билгийн үгсийн дагуу буюу; тиймийн тул энэ нь үнэний дагуу байг. Мөн тийн шүүгчдийн засаглалын тав дахь он төгсөв.

БҮЛЭГ 4

Алма мянга мянган хөрвөгчид баптисм хүртээв—Алдас Сүмд нэвтэрч, мөн Сүмийн дэвшил саатуулагдав—Нифайха ерөнхий шүүгчээр томилогдов—Алма, дээд санваартны хувьд, өөрийгөө тохинуулалд зориулав. Ойролцоогоор мэв 86–83 он.

Эдүгээ улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын зургадугаар онд, “Зарахемлагийн нутагт тэмцлүүд ч мөн дайнууд ч байсангүй;

2 Гэвч хүмүүс зүдэрч байв, тийм ээ, ах дүүсээ “алдсаны учир, мөн түүнчлэн бог мөн бод малаа алдсаны учир, мөн түүнчлэн леменчүүдийн хөл дор гишгэгдэж мөн устгагдсан үр тарианы талбайнуудаа алдсан учир маш ихээр зүдэрч байсан бөлгөө.

3 Мөн тэдний зүдгүүрүүд тийм агуу их байсны улмаас бодгаль бүхэнд гашуудах

20a Алма 2:24.
22a Алма 2:29–33.
26a су Ажлууд.
27a Ром 6:16;
Хил. 14:29–31.

су Дуулгавартай
байх, Дуулгавартай,
Дуулгавартай
дагах.
б Мозая 2:31–33;

Алма 5:41–42.
4 1a Омнай 1:12–19.
2a Алма 2:19; 3:1–2, 26.

шалтгаан болов; мөн энэ нь тэдний ёс бус хийгээд мөн тэдний жигшүүрт хэргүүдийн учир тэдэн дээр илгээгдсэн Бурханы шүүлтүүд байсан гэдэгт тэд итгэжээ; тиймийн тул тэд үүргийнхээ санамжинд сэрээгдсэн болой.

4 Мөн тэд сүмийг илүү бүрнээр нь байгуулж эхлэв; тийм ээ, мөн Сидоны усанд олон нь “баптисм хүртэж мөн Бурханы сүмд нэгдэв; тийм ээ, эцэг Алмагийнхаа гараар, сүмийн хүмүүсийн дээр ^бдээд санваартнаар ариулан адислагдсан Алмагийн гараар тэд баптисм хүртсэн ажээ.

5 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын долоо дахь жилд өөрсдийгөө Бурханы “сүмд нэгтгэж мөн баптисм хүртсэн гурван мянга таван зуу орчим бодгаль байв. Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын долоо дахь он төгсөв; мөн тэр бүх үед үргэлжийн амгалан байв.

6 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын найм дахь онд, өөрсдийн хөдөлмөрөөр олж авсан тэр үлэмжийн их “баялаг, мөн ^бсайн чанарын торгонууд, мөн нарийн нэхээст эдийнхээ учир, мөн олон бог мөн бод мал, мөн алт болон мөнгөнийхөө, мөн төрөл бүрийн үнэт зүйлүүдийнхээ учир сүмийн

хүмүүс бардам сэхүүн болж эхлэв; мөн эдгээр бүх зүйлийн учир тэд нүдэн дэх бардамналдаа хөөрсөн байв, учир нь тэд үлэмж үнэтэй хувцас өмсөж эхлэв.

7 Эдүгээ энэ нь Алмад, тийм ээ, мөн сүмийн багш нар, мөн санваартнууд, мөн ахлагчид байхаар Алмагийн “томилсон тэдгээр хүмүүсийн олонд нь их зүдгүүрийн шалтгаан байв; тийм ээ, тэдний олон нь өөрсдийн хүмүүсийн дунд эхэлсэн ёс бусыг харсан учир ихээр шаналж байв.

8 Учир нь сүмийн хүмүүс өөрсдийн нүдэн дэх “бардамналдаа хөөрцөглөж, мөн зүрх сэтгэлээ баялаг дээр мөн дэлхийн дэмий хоосон зүйлүүд дээр суурилуулж эхэлсэн аж, тиймээс тэд бие биенээ тохуурхах болов, мөн тэдний хүсэл мөн тааллын дагуу ^бсүсэглээгүй тэднийг хавчиж эхэлснийг их харамсалтайгаар тэд харж бас болгоов.

9 Мөн тийн, шүүгчдийн засаглалын энэ найм дахь онд, сүмийн хүмүүсийн дунд их “тэмцлүүд гарч эхлэв; тийм ээ, ^батаа жөтөө мөн маргаан мэтгэлцээн, мөн өс хонзон, мөн хавчлага, мөн бардамнал, бүр Бурханы сүмд харьяалагдаагүй тэднийхээс илүү бардамнал байлаа.

10 Мөн тийн шүүгчдийн засаглалын найм дахь он

4а Мозая 18:10–17.

б Мозая 29:42.

5а Мозая 25:18–23;

3 Ниф. 26:21.

6а су Баялгууд.

б Алма 1:29.

7а су Эрх мэдэл.

8а су Бардамнал;

Хоосон үг, Хоосон

үг ярих.

б Алма 1:21.

9а су Уруу таталт.

б су Атаархал.

төгсөв; мөн сүмийн ёс бус сүмд харьяалагдаагүй тэдэнд агуу тээглэх чулуу болж байв; мөн тийн сүм дэвшилдээ удааширч эхлэв.

11 Мөнхүү улиран тохиох дор ес дэх жилийн эхлэлд, Алма сүмийн ёс бус байдлыг харав, мөн түүнчлэн сүмийн тэр “үлгэр жишээ нь үл итгэгчдийг нэг алдсаас нөгөөд удирдаж эхлэн, тийн хүмүүсийн устгалыг ойртуулж буйг тэрээр үзэв.

12 Тийм ээ, тэрээр хүмүүсийн дундах агуу тэгш бус байдлыг, зарим нь өөрсдийн нүдэн дэх бардамналдаа хөөрч, бусдыг гадуурхаж, “гачигдсан мөн нүцгэн мөн” өлсгөлөн тэдэнд, мөн цангасан тэдэнд, мөн өвдөж зовсон тэдэнд араа харуулахыг харав.

13 Эдүгээ энэ нь хүмүүсийн дунд агуу харамсал гашуудлын шалтгаан болж байв, бусад зарим нь өөрсдийгөө даруухнаар үзэж, өөрсдийн хөрөнгийг ядуус хийгээд гачигдагсдад “хүртээн, өлссөнийг хооллох зэргээр, тэдний халамжаар гачигдах тэднийг халамжилж, мөн бүх төрлийн” зүдрэлийг бошиглолын суу билгийн дагуу ирэх ёстой тэр, Христийн “төлөө тэсвэрлэсэн буюу;

14 Тэр өдрийг харуулдан хүлээж; Есүс Христ үхлийн

хүлээснээс чөлөөлөх явдал мөн хүч чадал мөн тааллын дагуу, үхэгсдийн амилуулалтын учир агуу их “баяслаар дүүргэгдэж байх зуур, тийн нүглүүдийнхээ ангижралыг” хадгалсан ажгуу.

15 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма, Бурханы даруухан дагалдагчдын зовлонгуудыг мөн бусад хүмүүсийнхээ тэдний дээр овоолсон тэр хавчлагуудыг харж, мөн тэдний бүх “тэгш бус байдлыг харсан учир, маш их харамсаж эхлэв; гэсэн хэдий ч Их Эзэний Сүнс түүнийг орхисонгүй.

16 Мөн тэрээр сүмийн ахлагчдын дунд байсан мэргэн нэгнийг сонгон авч, мөн өгөгдсөн “хуулиудын дагуу тэрээр хуулиудыг тогтоож, мөн тэдгээрийг хүмүүсийн ёс бус байдал хийгээд гэмт хэргүүдийн дагуу хэрэгжүүлэх хүчтэй байж болохын тулд хүмүүсийн” саналын дагуу түүнд хүчийг өгөв.

17 Эдүгээ энэ хүний нэр Нифайха байв, мөн тэрээр “ерөнхий шүүгчээр томилогдов; мөн тэр хүмүүсийг шүүж мөн засаглахаар шүүгчийн суудалд суув.

18 Эдүгээ Алма сүмийн дээрх дээд санваартны албыг түүнд өгсөнгүй, харин тэр дээд санваартны албыг өөртөө хадгалж үлдээв; гэвч тэр

11a 2 Сам. 12:14;

Алма 39:11.

12a Иса. 3:14;

Иаков 2:17.

б Мозая 4:26.

13a су Өглөг, Өглөг

өгөх.

б су Дайсан.

в 2 Кор. 12:10.

14a су Баяр баясгалан.

б Мозая 4:12;

Алма 5:26–35.

су Зөвтгөл,

Зөвтгөх.

15a С ба Г 38:27; 49:20.

16a Алма 1:1, 14, 18.

б Алма 2:3–7.

17a Алма 50:37.

шүүгчийн суудлыг Нифайхад өгсөн бөлгөө.

19 Мөн тэр ^аөөрөө хүмүүсийнхээ дунд, өөрөөр хэлбэл Нифайн хүмүүсийн дунд одож болохын тулд, тэдэнд үүргийг нь ^бсануулахаар ^вөдөөж, тэдэнд ^гБурханы үгийг номлож болохын тулд, мөн түүний хүмүүсийн дунд байсан бүх бардамнал мөн башир арга хийгээд бүх тэмцлүүдийг Бурханы үгээр намжааж болохын тулд тэрээр үүнийг хийсэн болой, учир нь тэдний эсрэг шударга ^дгэрчлэлийг үзүүлэхээс бусдаар тэднийг буцааж авах өөр замыг тэр харсангүй.

20 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын ес дэх жилийн эхлэлд, Алма шүүгчийн суудлыг “Нифайхад дамжуулж, мөн өөрийгөө тэр чигээр нь Бурханы ариун жаягийн ^едээд санваарт, илчлэлтийн мөн бошиглолын суу билгийн дагуу, үгийн гэрчлэлд зориулав.

Бурханы ариун жаягийн дагуу Дээд санваартан болох Алмагийн уг нутаг даяар тэдний хотууд мөн тосгодын хүмүүст хүргэсэн үгс оршвой.

5 дугаар бүлэгт агуулагдсан.

БҮЛЭГ 5

Авралыг олохын тулд, хүмүүс наманчилж мөн зарлигуудыг дагах, дахин төрөх, өмсгөлүүдээ Христийн цусаар цэвэрлэх, даруу байж мөн өөрсдийгөө бардамнал мөн атаа жөтөөнөөс ангижруулах, зөв шударгын ажлуудыг хийх ёстой — Сайн Хоньчин өөрийн хүмүүсийг дууддаг — Хилэнцэт үйлүүдийг үйлдэх тэд чөтгөрийн хүүхдүүд болой — Алма сургаалынхаа үнэнийг гэрчилж мөн хүмүүнд наманчлахыг зарлиглав — Зөв шударгыг үйлдэгчдийн нэрс амьдралын номонд бичигдэх болно. Ойролцоогоор мээ 83 он.

Эдүгээ улиран тохиох дор Алма хүмүүст Бурханы “үгийг, эхлээд Зарахэмлагийн нутагт, мөн тэндээсээ бүх нутаг даяар ^жхүргэж эхлэв.

2 Мөн Зарахемла хотод байгуулагдсан сүмийн хүмүүст түүний ярьсан үгс нь эдгээр бөлгөө, түүний өөрийнх нь цэдгийн дагуу, өгүүлсэн нь:

3 Би, Алма, өөрийн эцэг Алмагаар Бурханы сүмийн дээрх ^здээд санваартан байхаар ^дтомилогдон адислагдсан билээ, учир нь түүнд эдгээр зүйлийг хийх хүч чадал мөн ^еэрх мэдэл Бурханаас өгөгдсөн юм, болгоогтун, тэр Нифайн хилийн дотор байсан ^жнутагт тэрээр сүм

19а Алма 7:1.
б Мозая 1:17; Хил. 12:3.
в Инос 1:23.
г Алма 31:5;
д ба Г 11:21–22.
е су Гэрчлэл.

20а Алма 8:12.
б Мозая 29:42;
Алма 5:3, 44, 49.
5 1а Алма 4:19.
б Алма 5:61.
3а Алма 4:4, 18, 20.

б су Томилох,
Томилолт.
в Мозая 18:13;
3 Ниф. 11:25.
г Мозая 18:4;
3 Ниф. 5:12.

байгуулж эхэлснийг би та нарт хэлнэ; тийм ээ, Мормоны нутаг гэж нэрлэгдсэн тэрхүү нутагт; тийм ээ, мөн тэрээр ах дүүстээ Мормоны Усанд баптисм хүртээсэн болой.

4 Мөн болгоогтун, би та нарт хэлнэ, тэд Бурханы нигүүлсэл мөн хүчээр, хаан Ноагийн хүмүүсийн гараас “чөлөөлөгдсөн билээ.

5 Мөн болгоогтун, түүний дараа, тэд аглаг буйдад леменчүүдийн гараар “дарангуйлалд авчрагдсан юм; тийм ээ, би та нарт хэлнэ, тэд боолчлолд байв, мөн Их Эзэн тэднийг өөрийн үгний хүчээр ⁶дарангуйллаас дахин чөлөөлсөн болой; мөн бид энэ нутагт авчрагдаж, мөн энд бид Бурханы сүмийг түүнчлэн энэ бүх нутаг даяар байгуулж эхэлсэн билээ.

6 Мөн эдүгээ болгоогтун, би та нарт хэлнэ, ах дүүс минь, энэ сүмд харъяалагддаг та нар, та нар эцэг өвгөдийнхөө боолчлолыг хангалттайгаар санасаар байдаг уу? Тийм ээ, мөн тэдэнд хандсан түүний нигүүлсэл хийгээд гэсвэрийг та нар хангалттайгаар санасаар байдаг уу? Мөн үүнээс гадна, та нар тэдний бодгалиудыг тэрээр тамаас чөлөөлснийг хангалттай санасаар байдаг уу?

7 Болгоогтун, тэрээр тэдний зүрх сэтгэлийг өөрчилсөн, тийм ээ, тэр тэднийг гүн

нойрноос сэрээсэн, мөн тэд Бурханы хувьд сэрсэн. Болгоогтун, тэд харанхуйн дунд байсан; гэсэн хэдий ч, тэдний бодгалиуд үүрдийн үгийн гэрлээр гэрэлтүүлэгдсэн билээ; тийм ээ, тэд “үхлийн хүлээсээр, мөн ⁶тамын гинжээр ороогдсон байж, мөн үүрдийн устгал тэднийг хүлээж байв.

8 Мөн эдүгээ би та нараас асууя, ах дүүс минь, тэд устгагдсан уу? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй, тэд устгагдаагүй.

9 Мөн үүнчлэн би асууна, үхлийн хүлээс таслагдаж мөн тэднийг ороосон тамын гинжүүд, тэдгээр нь тайлагдсан уу? Би та нарт хэлнэ, Тийм ээ, тэдгээр нь тайлагдсан, мөн тэдний бодгалиуд баясалд тэлж, мөн тэд гэтэлгэх хайрыг дуулах болов. Мөн тэд аврагдсаныг би та нарт хэлнэ.

10 Мөн эдүгээ тэд ямар нөхцөлийн дор “аврагдсаныг би та нараас асууя? Тийм ээ, авралын төлөө найдах ямар үндэслэл тэдэнд байгаа билээ? Тэднийг үхлийн хүлээснээс, тийм ээ, мөн түүнчлэн тамын гинжнээс сулласан шалтгаан нь юу билээ?

11 Болгоогтун, би та нарт хэлж чадна — “Абинадайн амаар яригдсан үгсэд миний эцэг Алма итгээгүй гэж үү? Мөн тэрээр ариун бошиглогч байгаагүй гэж үү? Тэрээр Бурханы үгсийг ярьж,

4а Мозая 23:1–3.

5а Мозая 23:37–39;
24:8–15.

б Мозая 24:17.

7а Мозая 15:8.

б Алма 12:11;
С ба Г 138:23.

10а су Аврал;

Гэтэлгэлийн
төлөвлөгөө.

11а Мозая 17:1–4.

тэгээд миний эцэг Алма тэдгээрт итгээгүй гэж үү?

12 Мөн өөрийнх нь итгэлийн дагуу түүний зүрх сэтгэлд хүчит “өөрчлөлт бий болгогдсон бөлгөө. Болгоогтун, энэ бүгд үнэнийг би та нарт хэлнэ.

13 Мөн болгоогтун, тэрээр та нарын эцэг өвгөдөд үгийг “номлож, мөн түүнчлэн тэдний зүрх сэтгэлд ч хүчит өөрчлөлт бий болгогдож, мөн тэд өөрсдийгөө даруусган мөн үнэн болоод “амьд Бурханд “найдлагаа тавьсан бөлгөө. Мөн болгоогтун, тэд “эцсийг хүртэл итгэлтэй байсан; тиймийн тул тэд аврагдав.

14 Мөн эдүгээ болгоогтун, би та нараас асууя, сүмийн ах дүүс минь, та нар сүнслэг байдлаараа Бурханаас “төрсөн үү? Та нар түүний дүр төрхийг царай төрхөндөө хүлээж авсан уу? Та нар энэ хүчит “өөрчлөлтийг зүрх сэтгэлээрээ эдэлсэн үү?

15 Та нарыг “бүтээсэн түүний гэтэлгэлд та нар итгэлийг хөгжүүлдэг үү? Та нар итгэлийн нүдээр урьдаас харж энэ зуурдын бие үхэшгүй байдалд “босгогдохыг, мөн энэ ялзрал муудашгүй болыхыг, Бурханы өмнө зуурдын биед байхдаа хийсэн үйлүү-

дийнхээ дагуу “шүүгдэхээр зогсохыг төсөөлдөг үү?

16 Би та нарт хэлнэ, та нар тэр өдөр: “Адислагдсан та нар надад ирэгтүн, учир нь болгоогтун, газар дэлхийн гадаргуу дээрх та нарын үйлүүд зөв шударгын үйлс байлаа хэмээн та нарт хэлэх Их Эзэний дуу хоолойг сонсоно хэмээн өөрсдөдөө төсөөлж чадах уу?

17 Эсвээс та нар тэр өдөр— Их Эзээн, бидний үйлс газар дэлхийн гадаргуу дээр зөв шударга байсан шүү дээ “хэмээн Их Эзэнд худал хэлэхэд— мөн тэр та нарыг аврах болно хэмээн өөрсдөдөө төсөөлдөг үү?

18 Эсвээс өөрөөр, та нарын бодгаль гэм болоод харамслаар дүүргэгдэж, өөрсдийн бүх гэмийн санамж, тийм ээ, өөрсдийн бүх ёс бусын төгс “санамж, тийм ээ, Бурханы зарлигуудыг дагахаас татгалзсаныхаа санамжтайгаар Бурханы индрийн өмнө аваачигдаж буйгаар та нар өөрсдийгөө төсөөлж чадах уу?

19 Би та нарт хэлнэ, тэр өдөр та нар ариун зүрх мөн цэвэр гартайгаар Бурхан өөд харж чадах уу? Би та нарт хэлнэ, Бурханы “дүр төрхийг царай төрхөндөө шингээгээд өөд харж чадах уу?

12a су Хөрвүүлэг,
Хөрвөгч.

13a Мозая 18:7.

б су Итгэл.

в Морм. 9:28;

С ба Г 20:19.

г су Тэвчих.

14a Мозая 27:24–27;

Алма 22:15.

су Дахин төрөх,
Бурханаас төрөх.

б Ром 8:11–17;

Мозая 5:2;

Мосе 6:65.

су Хөрвүүлэг,

Хөрвөгч.

15a су Бүтээх, Бүтээл.

б су Амилуулалт.

в су Эцсийн шүүлт.

16a Мат. 25:31–46.

17a 3 Ниф. 14:21–23.

18a Езек. 20:43;

2 Ниф. 9:14;

Мозая 3:25;

Алма 11:43.

19a 1 Иохан 3:1–3.

20 Би та нарт хэлнэ, та нар өөрсдийгөө чөтгөрийн “хараат болгохоор бууж өгчихөөд аврагдах талаар бодож чадах уу?

21 Би та нарт хэлнэ, та нар “аврагдаж чадахгүйгээ тэр өдөр мэдэх болно; учир нь ^бөмсгөлүүд нь цагаан болгож угаагдахаас бусдаар нэгээхэн ч хүмүүн аврагдаж чадахгүй; тийм ээ, өөрийн хүмүүсийг нүглүүдээс нь гэтэлгэхээр ирэх, бидний эцэг өвгөдөөр яригдсан түүний цусаар бүх толбоноос цэвэршигдэх хүртлээ өмсгөлүүд “ариутгагдах ёстой.

22 Мөн эдүгээ би та нараас асууя, ах дүүс минь, өмсгөлүүд тань “цусаар мөн бүх төрлийн ^ббузар муухайгаар толботуулагдсан байдалтайгаар та нар Бурханы тавцангийн өмнө зогсох болбол та нарын хэнд чинь ч гэсэн ямар санагдах билээ? Болгоогтун, эдгээр зүйлүүд та нарын эсрэг юуг гэрчлэх билээ?

23 Болгоогтун тэдгээр нь та нарыг алуурчид хэмээн, тийм ээ, мөн түүнчлэн та нарыг зүйл бүрийн ёсон бусын гэмтэй хэмээн “гэрчлэхгүй гэж үү?

24 Болгоогтун, ах дүүс минь, өмсгөлүүд нь цэвэрлэгдсэн мөн ямар ч толбогүй, цэвэр

мөн цагаан болох “Абрахамтай, Исаактай, мөн Иаковтай хамт мөн түүнчлэн бүх ариун бошиглогчидтой хамт, Бурханы хаант улсад суух газар тийм нэгэнд байж чадна гэж та нар боддог?

25 Би та нарт хэлнэ, Үгүй; Бүтээгчийг минь эхлэлээс худалч болгохоос, эсвэл эхлэлээс худалч байсан гэж бодохоос бусдаар, тиймүүд нь тэнгэрийн хаант улсад байрлаж чадна хэмээн та нар бодож болохгүй; харин тэд хөөгдөх болно, учир нь тэд чөтгөрийн “хаант улсын хүүхдүүд бөлгөө.

26 Мөн эдүгээ болгоогтун, би та нарт хэлнэ, ах дүүс минь, хэрэв та нар зүрх сэтгэлийн “өөрчлөлтийг эдэлсэн бол, мөн хэрэв та нар ^бгэтэлгэх хайрын дууг дуулмаар санагдсан бол, би асууя, та нар одоо тийн “мэдэрч чадна уу?

27 Та нар Бурханы өмнө өөрсдийгөө “өө сэвгүй байлган, алхалсан уу? Хэрэв та нар энэ цагт үхэхээр дуудагдвал, та нар хангалттай ^бдаруухан байсан хэмээн өөрсдөдөө хэлж чадах сан болов уу? Өөрийн хүмүүсийг нүглүүдээс нь “гэтэлгэхээр ирэх Христийн цусаар өмсгөлүүд тань цэвэршигдэж, цагаан болгогдсон гэх үү?

20a Мозая 2:32.

21a су Аврал.

б 1 Ниф. 12:10;

Алма 13:11–13;

3 Ниф. 27:19–20.

в су Цэвэр ариун,

Цэвэр ариун байдал.

22a Иса. 59:3.

б су Бузар, Бузар явдал.

23a Иса. 59:12.

24a Лук 13:28.

25a 2 Ниф. 9:9.

26a су Хөрвүүлэг,

Хөрвөгч.

б Алма 26:13.

в Мозая 4:12;

С ба Г 20:31–34.

27a су Зөвтгөл, Зөвтгөх.

б су Даруу, Даруу байдал.

в су Гэтэлгэх,

Гэтэлгэгдэх,

Гэтэлгэл.

28 Болгоогтун, та нар “бардамналаасаа ангижирсан уу? Би та нарт хэлнэ, хэрэв та нар тэгээгүй бол та нар Бурхантай уулзахад бэлтгэгдээгүй байна. Болгоогтун, та нар хурдхан бэлтгэх ёстой; учир нь тэнгэрийн хаант улс удахгүй ирнэ, мөн тийм нэгэн нь мөнх амьдралыг авахгүй болгоо.

29 Болгоогтун, би хэлнэ, та нарын дунд “атаа жөтөөнөөсөө ангижраагүй нэгэн байна уу? Тийм нэгэн нь бэлтгэгдээгүй хэмээн би та нарт хэлнэ; мөн би түүнийг хурдхан бэлтгээсэй хэмээнэ, учир нь цаг ойрхон болж, мөн тэрээр цаг нь хэзээ ирэхийг мэдэхгүй байгаа; учир нь тийм нэг нь гэмгүй хэмээн тогтоогдохгүй.

30 Мөн түүнчлэн би та нарт хэлнэ, та нарын дунд ах дүүсээрээ “доог хийдэг, эсвээс түүний дээр хавчлага овоолдог нэгэн нь байна уу?

31 Тийм нэгэнд халаг, учир нь тэр бэлтгэгдээгүй, мөн тэрээр наманчлах ёстой эс бөгөөс тэр аврагдаж чадахгүй тэр цаг ойрхон болжээ!

32 Тийм ээ, бүр “алдсыг үйлдэгчид та нарт бүгдэд нь халаг; наманчлагтун, наманч-

лагтун, учир нь Их Эзэн Бурхан үүнийг ярьсан билээ!

33 Болгоогтун, тэрээр “бүх хүмүүнд урилга илгээдэг, учир нь ⁶нигүүлслийн мутар тэдний зүг сунгагдаж, мөн тэрээр: Наманчлагтун, мөн би та нарыг хүлээн авах болно хэмээн хэлэх болно.

34 Тийм ээ, тэрээр хэлэв: Надад “ирэгтүн мөн та нар амьдралын модны ⁶үр жимснээс хүртэх болно; тийм ээ, та нар “үнэгүйгээр амьдралын ‘талх мөн уснаас идэж мөн уух болно;

35 Тийм ээ, надад ирэгтүн мөн зөв шударгын үйлүүдийг авчрагтун, мөн та нар цавчигдаж мөн галд хаягдахгүй байх болно—

36 Учир нь болгоогтун, сайн үр жимсийг “авчирдаггүй хэн боловч, өөрөөр хэлбэл зөв шударгын үйлүүдийг хийдэггүй хэн боловч, мөнхүү тэр нь орь дуу тавих мөн гашуудах шалтгаан бүхий байх тэр цаг ойрхон байнам.

37 Ай алдсыг үйлдэгчид та нар; дэлхийн “хоосон зүйлүүдээр ааглагдсан та нар, зөв шударгын замуудыг мэдсэн дүр эсгэдэг хэдий ч хоньчингүй ⁶хонь мэт “төөрч одсон, үнэн хэрэгтээ хоньчин та нарын араас дуудаж байсан мөн

28a су Бардамнал.

29a су Атаархал.

30a су Хилэнцэтийг ярих.

32a Дуул. 5:5.

33a Алма 19:36;

3 Ниф. 18:25.

б Иаков 6:5;

3 Ниф. 9:14.

34a 2 Ниф. 26:24–28;

3 Ниф. 9:13–14.

б 1 Ниф. 8:11; 15:36.

в 2 Ниф. 9:50–51;

Алма 42:27.

г су Амьдралын талх.

36a Мат. 3:10; 7:15–20;

3 Ниф. 14:19;

С ба Г 97:7.

37a су Хоосон үг,

Хоосон үг ярих.

б Мат. 9:36.

в 2 Ниф. 12:5; 28:14;

Мозая 14:6.

та нарын араас 'дуудсаар л буй, гэвч та нар түүний дуу хоолойг °сонсохгүй шүү дээ!

38 Болгоогтун, би та нарт хэлнэ, сайн “хоньчин та нарыг дууддаг; тийм ээ, мөн Христийн нэр болох өөрийнхөө °нэрээр та нарыг тэр дууддаг; мөн хэрэв та нар °сайн хоньчны дуу хоолойг, та нарын дуудагдах тэрхүү нэрийг °сонсохгүй бол, болгоогтун, та нар сайн хоньчны хонь биш.

39 Мөн эдүгээ хэрэв та нар сайн хоньчны хонь бус аваас, та нар аль “сүргийнх вэ? Болгоогтун, би та нарт хэлнэ, °чөтгөр бол та нарын хоньчин, мөн та нар түүний сүргийнх; мөн эдүгээ, үүнийг хэн үгүйсгэж чадах билээ? Болгоогтун, би та нарт хэлнэ, үүнийг үгүйсгэгч хэн боловч °худалч мөн °чөтгөрийн хүүхэд болой.

40 Учир нь “сайн бүхэн Бурханаас ирдэг, мөн хилэнцэт болох юу боловч чөтгөрөөс ирдгийг би та нарт хэлнэ.

41 Тиймийн тул, хэрэв хүмүүн нь “сайн ажлуудыг авчирваас тэрээр сайн хоньчны дуу хоолойг сонсож, мөн тэрээр түүнийг дагадаг; харин хилэнцэт үйлүүдийг авчрах хэн боловч, мөнхүү тэр нь

°чөтгөрийн хүүхэд болдог, учир нь тэрээр түүний дуу хоолойг сонсож, мөн түүнийг дагадаг.

42 Мөн үүнийг үйлдэгч хэн боловч “шан хөлсөө түүнээс хүлээн авах ёстой; тиймийн тул, бүх сайн үйлүүдийн хувьд үхмэл байдаг учир тэрээр зөв шударгад хамаарагдах зүйлүүдийн хувьд °хөлсөндөө °үхлийг хүлээн авдаг, бөлгөө.

43 Мөн эдүгээ, ах дүүс минь, та нар намайг сонсоосой хэмээнэ би, учир нь би бодгалийнхаа эрч хүчээр ярьж байна; учир нь болгоогтун, та нар алдах боломжгүйгээр би та нарт тодорхой ярьсан, өөрөөр хэлбэл Бурханы зарлигуудын дагуу ярьсан.

44 Учир нь би энэ маягаар, Христ Есүс дэх тэр “Бурханы ариун жаягийн дагуу ярихаар дуудагдсан; тийм ээ, би босч мөн энэ хүмүүст ирэх тэр зүйлүүдийн талаар бидний эцэг өвгөдөөр яригдсан тэр зүйлийг гэрчлэхээр зарлигдуулсан юм.

45 Мөн энэ нь бүгд биш. Би эдгээр зүйлүүдийн тухай өөрөө “мэддэг хэмээн та нар бодохгүй байна гэж үү? Болгоогтун, миний ярьсан эдгээр

37г Сур. үгс 1:24–27;
Иса. 65:12.

д Иер. 26:4–5;

Алма 10:6.

38а су Сайн Хоньчин.

б Мозая 5:8;

Алма 34:38.

в 3 Ниф. 15:24; 18:31.

г Лев. 26:14–20;

С ба Г 101:7.

39а Мат. 6:24;

Лук 16:13.

б Мозая 5:10.

су Чөтгөр.

в 1 Иохан 2:22.

г 2 Ниф. 9:9.

40а Омнай 1:25;

Ифер 4:12;

Моро. 7:12, 15–17.

41а 3 Ниф. 14:16–20.

су Ажлууд.

б Мозая 16:3–5;

Алма 11:23.

42а Алма 3:26–27;

С ба Г 29:45.

б Ром 6:23.

в Хил. 14:16–18.

су Сүнсний үхэл.

44а Алма 13:6.

45а су Гэрчлэл.

зүйлүүд үнэнийг би мэднэ хэмээн би та нарт гэрчилж байна. Мөн би тэдгээрийн гарцаагүйг яахан мэдэх билээ хэмээн та нар бодож байна уу ?

46 Болгоогтун, би та нарт хэлнэ тэдгээр нь Бурханы Ариун Сүнсээр надад “мэдүүлэгдсэн билээ. Болгоогтун, би өөрөө эдгээр зүйлийг мэдэж болохын тулд олон хоног ^бмацаг барьж бас залбирсан. Мөн эдүгээ би өөрөө тэдгээр нь үнэнийг мэднэ; учир нь Их Эзэн Бурхан өөрийн Ариун Сүнсээр надад тэдгээрийг үзүүлсэн юм; мөн энэ нь надад байгаа тэрхүү ^вилчлэлтийн суу билэг бөлгөө.

47 Мөн үүнээс гадна, энэ нь тийн надад илчлэгдсэнийг, бидний эцэг өвгөдөөр яригдсан тэрхүү үгс үнэн гэдгийг, бүр надад буй бошиглолын суу билгийн дагуу, түүнчлэн Бурханы Сүнсний илэрхийлэлтээр гэдгийг би та нарт хэлнэ.

48 Би та нарт хэлнэ, та нарт миний хэлэх юу боловч, ирэх тэрний тухайд тэр бүгд үнэн гэдгийг би өөрөө мэднэ; мөн би та нарт хэлнэ, Есүс Христ, тийм ээ, Хүү, Эцэгийн Төрсөн Ганц, ач ивээл, нигүүлсэл, мөн үнэнээр дүүрэн тэрбээр ирэх болно гэдгийг мэднэ

буюу. Мөн болгоогтун, дэлхийн нүглүүдийг, тийм ээ, түүний нэрэнд гуйвшгүйгээр итгэх хүн бүрийн нүглийг зайлуулан авахаар ирэх нь тэр бөлгөө.

49 Мөн эдүгээ энэ бол, тийм ээ, хайрт ах дүүстээ номлохоор, тийм ээ, энэ нутагт орших хүн бүрд; тийм ээ, настай болон залуу аль алинд нь, боол болон чөлөөт аль алинд нь бүгдэд номлохоор; тийм ээ, би та нарт хэлнэ, настан, мөн түүнчлэн дунд насныханд, мөн өсөх залуу үеийнхэнд, тийм ээ, тэд наманчилж мөн “дахин төрөх ёстой хэмээн тэдэнд тунхаглахаар үүний дагуу дуудагдсан тэрхүү ^бжаяг гэдгийг би та нарт хэлье.

50 Тийм ээ: Наманчлагтун, газар дэлхийн бүх хязгаарууд та нар, учир нь тэнгэрийн хаант улс удахгүй ирнэ; тийм ээ, Бурханы Хүү өөрийн “алдар суу, чадал, сүр жавхлан, хүч мөн эрх мэдэлтэйгээр ирэх болно хэмээн Сүнс хэлдэг. Тийм ээ, хайрт ах дүүс минь, би та нарт хэлнэ: Бүх газар дэлхийн ^бХааны алдар сууг болгоогтун; мөн түүнчлэн тэнгэрийн Хаан тун удахгүй хүмүүний бүх үрсийн дунд гэрэлтэх болно хэмээн Сүнс хэлдэг.

46a 1 Кор. 2:9–16.

^б су Мацаг барих, Мацаг барилт.

^в су Илчлэлт.

49a су Дахин төрөх, Бурханаас төрөх.

^б су Дуудах, Бурханаас

дуудагдах, Дуудлага; Санваартан.

50a су Алдар суу; Есүс Христийн Хоёр дахь Ирэлт.

^б Дуул. 24; Мат. 2:2; Лук 23:2;

2 Ниф. 10:14;

С ба Г 38:21–22;

128:22–23; Моисе 7:53.

су Есүс Христ;

Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс.

51 Мөн түүнчлэн Сүнс надад хэлэв, тийм ээ, надад хүчит дуугаар хашгирч өгүүлсэн нь: Явагтун мөн энэ хүмүүст хэл—Наманчлагтун, учир нь та нар наманчлахгүй аваас та нар “тэнгэрийн хаант улсыг өвлөж яавч чадахгүй.

52 Мөн үүнчлэн би та нарт хэлнэ: Болгоогтун, модны ёзоорт “сүх тавигдсан; тиймийн тул сайн үр жимс авчирдаггүй мод бүхэн ^бцавчигдаж мөн галд хаягдах болно, тийм ээ, шатаж үл дуусах тэр галд, бүр унтраагдашгүй галд хэмээн Сүнс хэлдэг. Болгоогтун, мөн санагтун, Ариун Нэгэн үүнийг ярьсан бөлгөө.

53 Мөн эдүгээ хайрт ах дүүс минь, би та нарт хэлнэ, та нар эдгээр хэлэгдсэнийг сөрж чадна гэж үү; тийм ээ, та нар эдгээр зүйлийг хойш тавьж, мөн Ариун Нэгэнийг хөл доороо “дэвсэлж чадна гэж үү; тийм ээ, та нар зүрх сэтгэл дэх ^ббардамналдаа хөөрч чадна гэж үү; тийм ээ, та нар цаашид “үнэт хувцас хунар өмсөж мөн зүрх сэтгэлээ дэлхийн хоосон зүйлүүд дээр, “баялгууд дээрээ тавьсаар л байх гэж үү?

54 Тийм ээ, та нар цаашид ч өөрсдийгөө нэг нь нөгөөгөөс илүү дээр хэмээн бодсоор л байх уу; тийм ээ, өөрсдийгөө даруусган мөн түүгээр тэд

энэ сүмд авчрагдсан Бурханы ариун жаягийн дагуу алхалж, Ариун Сүнсээр “ариусгагдаж, мөн наманчлалд нийцэх үйлүүдийг хийх ах дүүсээ та нар хавчин гадуурхсаар л байх уу—

55 Тийм ээ, мөн та нар “ядууст хийгээд гачигдагсдад араа харуулан эргэж, тэднээс хөрөнгөө харамласаар л байх гэж үү?

56 Мөн эцэст нь, ёс бус байдалдаа үлдэх та нар бүгд, эдгээр нь хурдхан наманчлахгүй аваас тас цавчигдаж мөн галд хаягдах тэдгээр юм гэдгийг би та нарт хэлье.

57 Мөн эдүгээ би та нарт хэлнэ, “сайн хоньчны дуу хоолойг дагахыг хүсэх та нар бүгд, ёс бусыг үйлдэгчдийн дундаас гарч ирцгээ, мөн та нар ^бтусдаа байгтун, мөн тэдний цэвэр бус зүйлүүдэд бүү хүрэгтүн; мөн болгоогтун, тэдний нэрс “арилгагдах болно, ёс бусыг үйлдэгчдийн нэрс зөв шударгыг үйлдэгчдийн нэрсийн дунд тоологдохгүйн тулд, Бурханы үг гүйцэлдэж болохын тулд бөлгөө: Ёс бусыг үйлдэгчдийн нэрс миний хүмүүсийн нэрстэй холилдохгүй байх болно хэмээн хэлсэнчлэнгээр буюу;

58 Учир нь зөв шударгыг үйлдэгчдийн нэрс “амьдралын

51a су Тэнгэр.

52a Лук 3:9; С ба Г 97:7.

б Иаков 5:46; 6:7;

3 Ниф. 27:11–12.

53a 1 Ниф. 19:7.

б су Бардамнал.

в 2 Ниф. 28:11–14;

Морм. 8:36–39.

г Дуул. 62:10;

С ба Г 56:16–18.

54a су Ариусгал.

55a Дуул. 109:15–16;

Иаков 2:17;

Хил. 6:39–40.

57a су Сайн Хоньчин.

б Езра 6:21; 9:1;

Нех. 9:2; 2 Тес. 3:6;

С ба Г 133:5, 14.

в Дэд хууль 29:20;

Моро. 6:7; С ба Г 20:8.

58a су Амьдралын ном.

номонд бичигдэх болно, мөн би тэдэнд өөрийн баруун гар дахь өвийг хайрлах болно. Мөн эдүгээ, ах дүүс минь, үүний эсрэг хэлэх юу та нарт буй билээ? Би та нарт хэлнэ, хэрэв та нар үүний эсрэг ярих аваас, тэр нь хамаагүй, учир нь Бурханы үг гүйцэлдэх ёстой.

59 Учир нь та нарын дунд чононууд орж мөн сүргийг нь цөлмөхгүйн тулд олон хоньтой ч тэднийгээ хариулдаггүй ямар хоньчин байх билээ? Мөн болгоогтун, хэрэв чоно сүрэгт нь орвол тэрээр түүнийг хөөхгүй гэж үү? Тийм ээ, мөн эцэст нь хэрэв тэр чадвал, тэрээр түүнийг устгах болно.

60 Мөн эдүгээ сайн хоньчин та нарын араас дууддагийг би та нарт хэлнэ; мөн хэрэв та нар түүний дуу хоолойг сонсвол тэрээр та нарыг сүрэгтээ авчрах болно мөн та нар түүний хонь билээ; мөн та нар устгагдахгүй байж болохын тулд та нар өөрсдийнхөө дунд араатан чоно орохыг үл зөвшөөр хэмээн тэрээр та нарт зарлигласан билээ.

61 Мөн эдүгээ би, Алма, надад зарлигласан “түүний хэлээр, та нарт миний ярьсан үгсийг мөрдөхийг та нарт зарлиглаж байна.

62 Сүмд харъяалагдах та нарт би зарлигийн замаар

ярина; мөн сүмд харъяалагдаагүй тэдэнд би урилгын замаар ярина, хэлрүүн: Та нар түүнчлэн “амьдралын модны жимснээс хүртэгсэд байж болохын тулд ирэгтүн мөн наманчлалд баптисм хүртэгтүн.

БҮЛЭГ 6

Зарахемла дахь Сүм цэвэршигдэж мөн журам тогтоогдов— Алма номлохоор Гидеонд очив. Ойролцоогоор мээ 83 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Алма Зарахемлагийн хотод байгуулагдсан, сүмийн хүмүүст ярихаа төгсгөл болгосны дараа, тэрээр Бурханы жаягийн дагуу “гараа тавин, сүмийн дээр тэргүүлэх мөн ⁶хянах санваартнууд хийгээд ⁶ахлагчдыг ⁷томилов.

2 Мөнхүү улиран тохиох дор сүмд харъяалагдаагүй, нүглээ наманчилсан болгон нь, наманчлалд “баптисм хүртэж, мөн сүмд хүлээн зөвшөөрөгдөв.

3 Мөн түүнчлэн улиран тохиох дор сүмд харъяалагдаж байсан ч өөрсдийн ёс бусыг “наманчилж мөн Бурханы өмнө өөрсдийгөө даруусгаагүй хэн боловч—зүрх сэтгэл дэх ⁶бардамналдаа хөөрсөн тэднийг би хэлж байна— мөнхүү тэд нь гологдож, мөн зөв шударгыг үйлдэгсдийн

61a Алма 5:44.

62a 1 Ниф. 8:10; 11:21–23.

6 1a су Гар тавих.

6 С ба Г 52:39.

6 су Ахлагч.

7 су Томилох,

Томилолт.

2a су Баптисм,

Баптисм хүртээх.

3a Мозая 26:6.

6 су Бардамнал.

дунд тоологдохгүйн тулд тэдний нэрс “арилгагдсан бөлгөө.

4 Мөн тэд тийн Зарахемлагийн хотод сүмийн жаягийг үндэслэж эхлэв.

5 Эдүгээ Бурханы үг бүгдэд чөлөөтэй тул Бурханы үгийг сонсохоор хамтран чуулах хэний ч боломж булаагдаагүйг та нар ойлгоосой хэмээнэ би.

6 Гэсэн хэдий ч Бурханы хүүхдүүд ойр ойрхон нэгдэн цугларцгааж, мөн Бурханыг мэдэхгүй тэдний бодгалиудын аз жаргалын төлөө “мацаг барих болон хүчирхэг залбиралд нэгдэхээр зарлигдуулсан билээ.

7 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма эдгээр зохицуулалтыг хийгээд тэрээр тэднээс салж одлоо, тийм ээ Зарахемлагийн хотод байсан тэр сүмээс, мөн Сидон голын зүүнтээ гарч, “Гидеоны хөндийд очлоо, тэнд Нихорын гараар илдэнд “хөнөөгдсөн тэр хүний нэрээр, Гидеон гэж нэрлэгдсэн тэр хөндийд, Гидеоны хот гэж нэрлэгдсэн нэг хот баригдсан байсны улмаас буюу.

8 Мөн Алма явж мөн эцэг өвгөдөөрөө яригдсан тэрхүү үгийн үнэн гэсэн илчлэлтийн дагуу, мөн нүглүүдээс нь өөрийн хүмүүсийг гэтэлгэхээр ирэх Бурханы Хүү, Есүс Христийн талаарх “гэрчлэлийн дагуу, өөрт нь байх тэрхүү

бошиглолын суу билгийн дагуу, мөн өөрийн дуудагдсан тэр ариун жаягийн дагуу Бурханы үгийг Гидеоны хөндийд байгуулагдсан сүмд тунхаглаж эхлэв. Мөн тийн бичигдсэн болой. Амен.

Гидеон дахь хүмүүст түүний хүргэсэн Алмагийн тэр үгс, түүний өөрийнх нь цэдгийн дагуу оршвой.

7 дугаар бүлэгт агуулагдав.

БҮЛЭГ 7

Христ Мариагаас төрөх болно — Тэрээр үхлийн хүлээсийг тайлж мөн өөрийн хүмүүсийн нүглүүдийг үүрэх болно — Наманчилж, баптисм хүртэж, мөн зарлигуудыг дагадаг нь мөнхийн амьдралыг авах болно — Бузар муухай нь Бурханы хаант улсыг өвлөж чадахгүй — Даруу байдал, итгэл, найдвар мөн энэрэл шаардагдана. Ойролцоогоор мээ 83 он.

Болгоогтун хайрт ах дүүс минь, би та нар дээр ирэх боломжтой болсны учир, тиймийн тул би өөрийн хэлээр та нарт “ярихыг оролдоё; тийм ээ, өөрийн амаар, би “шүүгчийн суудалд бүрэн баригдаж, би та нарт ирж чадахааргүй их ажилтай байсан учир, энэ бол би анх удаа та нарт хандан өөрийн

3в Ег. 32:33;
Мозая 26:36;
Алма 1:24; 5:57–58.
су Сүмээс хөөх.

6а су Мацаг барих,
Мацаг барилт.
7а Алма 2:20.
б Алма 1:9.

8а Илч. 19:10.
7 1а Алма 4:19.
б Мозая 29:42.

амны үгсээр ярьж байгаагийн учир буюу.

2 Мөн хэрэв шүүгчийн суудал миний оронд засаглах өөр нэгэнд “өгөгдөөгүй байсан бол бүр энэ цагт ч гэсэн би ирж чадахгүй байх сан; мөн Их Эзэн их нигүүлслээр намайг та нар дээр ирэхийг минь зөвшөөрсөн билээ.

3 Мөн болгоогтун, та нар өөрсдийгөө Бурханы өмнө даруусгаг, мөн та нар түүний ач ивээлийг гуйсаар л буйг олж мэдэх юм сан, би та нарыг түүний өмнө буруугүй байхыг олж мэдэх юм сан, би та нарыг Зарахемла дахь бидний ах дүүсийн адил хүнд байдалд ороогүй байгааг олж мэдэх юм сан гэсэн агуу их найдлага мөн ихээхэн хүсэлтэйгээр ирсэн билээ би.

4 Гэвч Бурханы нэр алдаршиг, учир нь тэрээр надад мэдүүлж өгсөн билээ, тийм ээ, тэд дахин түүний зөв шударгын замд оруулагдсаныг нь мэдүүлэн үлэмж агуу баяслыг надад өгсөн билээ.

5 Мөн надад орших Бурханы Сүнсний дагуу, би түүнчлэн та нарын төлөө баясах болно гэдэгт би найдаж байна; гэсэн хэдий ч та нарын төлөө баясах миний баясал Зарахемла дахь ах дүүсийн төлөө надад байсан шиг тийм их зүдрэлүүд мөн харууслыг туулснаас ирээсэй хэмээн би хүсэхгүй байна, учир нь болгоогтун, тэдний төлөө

миний баясал нь их зүдрэл мөн харууслыг туулсны дараа ирсэн бөлгөө.

6 Гэвч болгоогтун, би та нарыг өөрсдийн ах дүүсийн адил тийм ч их итгэлгүй байдалд ороогүй байх хэмээн найдаж байна; би та нарыг зүрх сэтгэлийнхээ бардамналд хөөрөөгүй хэмээн найдаж байна; тийм ээ, би та нарыг зүрх сэтгэлээ дэлхийн хоосон зүйлүүд дээр мөн баялгууд дээр тавиагүй хэмээн найдаж байна; тийм ээ, би та нарыг “хиймэл шүтээн шүтдэггүй, харин үнэн бөгөөд амьд Бурханыг шүтэж, мөн хойшид ирэх нүглүүдийнхээ ангижралыг үүрдийн итгэлтэйгээр харуулдан хүлээсээр буй гэдэгт найдаж байна би.

7 Учир нь болгоогтун, би ирэх олон зүйл буйг та нарт хэлнэ; мөн болгоогтун, тэд бүгдээс илүү чухал нэгэн зүйл буй — учир нь болгоогтун, Гэтэлгэгч өөрийн хүмүүсийн дунд ирж мөн амьдрах тэрхүү “цаг тийм ч холгүй болжээ.

8 Болгоогтун, тэрээр өөрийн зуурдын асарт орших цагтаа бидний дунд ирэх болно гэж би хэлээгүй; учир нь болгоогтун, энэ нь нөхцөл байхыг Сүнс надад хэлсэнгүй. Эдүгээ энэ зүйлийн хувьд би мэдэхгүй; гэвч энэ зэргийг, Их Эзэн Бурхан өөрийн үгийн дагуу тэр бүх зүйлийг хийх хүчтэйг би мэднэ.

9 Гэвч болгоогтун, Сүнс надад энэ зэргийг хэлж, өгүүлсэн нь: Энэ хүмүүст хашгирч, хэлэгтүн—“Наманчлагтун та нар, мөн Их Эзэний замыг бэлтгэ, мөн шулуун болох түүний замуудаар алхагтун; учир нь болгоогтун тэнгэрийн хаант улс ойртож байна, мөн Бурханы Хүү дэлхийн гадаргуу дээр ^бирэх болно.

10 Мөн болгоогтун, тэр бидний эцэг өвгөдийн “нутаг болох тэр Иерусалимд, ^бМариагаас ^бтөрөх болно, тэр нь ^бонгон бүсгүй, Ариун Сүнсний хүчээр бүрхэгдэж мөн ^бхөл хүнд болгогдож, мөн хүү төрүүлэх, тийм ээ, бүр Бурханы Хүүг тээгч болж сонгогдсон мөн хонгорхон нэгэн байх болно.

11 Мөн тэрээр бүх төрлийн өвчин мөн “зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчих болно; мөн энэ нь тэр өөрийн хүмүүсийн шаналал мөн өвчнүүдийг өөр дээрээ авах болно гэсэн тэрхүү үг биелэгдэж болохын тулд бөлгөө.

12 Мөн тэрээр “үхлийг өөр дээрээ авах болно, тэр өөрийнх нь хүмүүсийг хүлсэн тэрхүү үхлийн хүлээсийг тайлж болохын тулд бөлгөө; мөн түүний зүрх сэтгэл бие

махбодийн дагуу нигүүлслээр дүүргэгдэж болохын тулд, тэрээр бие махбодийн дагуу өөрийн хүмүүсийг тэдний сул байдлуудынх нь дагуу хэрхэн ^бхаламжлахыг мэдэж болохын тулд, тэрээр өөр дээрээ тэдний сул дорой чанаруудыг авах болно.

13 Эдүгээ Сүнс бүх зүйлийг “мэддэг; гэсэн хэдий ч Бурханы Хүү өөрийн хүмүүсийн нүглүүдийг өөр дээрээ ^бавч болохын тулд, тэрээр өөрийн чөлөөлөлтийн хүчний дагуу тэдний зөрчлүүдийг арилгаж болохын тулд бие махбодийн дагуу зовох болно; мөн эдүгээ болгоогтун, надад буй гэрчлэл нь энэ болой.

14 Эдүгээ та нар наманчилж, мөн “дахин төрөх ёстойг би та нарт хэлнэ; учир нь хэрэв та нар дахин төрөхгүй бол тэнгэрийн хаант улсыг өвлөж чадахгүй хэмээн Сүнс хэлдэг; тиймийн тул ирэгтүн мөн наманчлалд баптисм хүртэгтүн, та нар нүглүүдээсээ угаагдаж болохын тулд, та нар дэлхийн нүглүүдийг зайлуулах, зөв шударга бус бүхнээс цэвэрлэж мөн аврах чадалтай, Бурханы Хурганд итгэлтэй байж болохын тулд бөлгөө.

15 Тийм ээ, ирэгтүн мөн бүү

9а Мат. 3:2–4;
Алма 9:25.

б Мозая 3:5; 7:27;
15:1–2.

10а Шаст. дээд 9:3;
Шаст. дэд 15:9;
1 Ниф. 1:4;
3 Ниф. 20:29.

б Мозая 3:8.

су Мариа, Есүсийн эх.

в Иса. 7:14;
Лук 1:27.

г 1 Ниф. 11:13–21.

д Мат. 1:20;

Мозая 15:3.

11а Иса. 53:3–5;
Мозая 14:3–5.

12а 2 Ниф. 2:8;

Алма 12:24–25.

су Цовдлуулалт.

б Евр. 2:18; 4:15;
С ба Г 62:1.

13а су Бурхан, Бурхан
тэргүүтэн.

б Мозая 15:12.
су Цагаатгах,
Цагаатгал.

14а су Дахин төрөх,
Бурханаас төрөх.

эмээ, мөн та нарыг амархан “дайрах, та нарыг доош устгалд хүргэхээр хүлэх нүгэл бүрийг хойш тавь хэмээн би та нарт хэлнэ, тийм ээ, ирэгтүн мөн үйлдэгтүн, мөн Бурхандаа та нар нүглээ нанманчилж мөн түүний зарлигуудыг дагахаар түүнтэй гэрээ хийхэд бэлэн байгаагаа үзүүлж, мөн үүнийгээ энэ өдөр баптисмын усанд орсноор түүнд гэрчлэгтүн.

16 Мөн үүнийг үйлдсэн мөн тэр цагаас Бурханы зарлигуудыг дагасан хэн боловч, мөнхүү тэр нь өөрт нь миний хэлснийг санах болно, надад гэрчлэх тэр Ариун Сүнсний гэрчлэлийн дагуу тэрээр мөнх амьдралыг авах болно тийм ээ, хэмээн түүнд миний хэлснийг тэрээр санах болно.

17 Мөн эдүгээ хайрт ах дүүс минь, та нар эдгээр зүйлд итгэдэг үү? Болгоогтун, би та нарт хэлнэ, тийм ээ, та нарыг тэдгээрт итгэдгийг би мэднэ; мөн та нарын тэдгээрт итгэж буйг миний мэдсэн зам нь надад байх Сүнсний үзүүлснээр болой. Мөн эдүгээ миний ярьсан зүйлүүдийн талаар, тийм ээ, түүний талаарх та нарын итгэл хүчтэйн учир миний баясал агуу их болой.

18 Учир нь та нарыг ах дүүсийнхээ адил хүнд байдалд бүү байгаасай гэсэн их хүсэл надад байсныг би та нарт

эхлэлээс хэлсэн лугаа адил, үүнчлэн миний хүсэл хангагдсаныг би олж мэдлээ.

19 Учир нь та нар зөв шударгын замууд дээр буйг би ухамсарлаж байна; та нар Бурханы хаант улс тийш удирдах зам дээр байгааг би ухамсарлаж байна; тийм ээ, та нар түүний “замуудыг шулуутган үйлдэж буйг би ухамсарлав.

20 Тэрээр муруй тахир замуудаар “алхаж чадахгүй нь түүний үгийн гэрчлэлээр та нарт мэдүүлэгдсэнийг би ухамсарлав; тэрээр өөрийн хэлснээс буцах нь ч үгүй; бас түүнд баруунаас солгой гар тийш, өөрөөр хэлбэл зөв болох түүнээс буруу болох түүний тийш эргэхийн сүүдэр ч үгүй байдаг; тиймийн тул, түүний замнал нэгэн мөнхийн эргэлт авай.

21 Мөн тэрээр “ариун бус сүмүүдэд орших нь үгүй; бас Бурханы хаант улсад бузар эсвээс цэвэр бус нэг ч зүйл хүлээн авагдаж чадахгүй; тиймийн тул, “бузар нэг нь өөрийн бузар байдалдаа үлдэх тэр цаг ирэх болно, тийм ээ, мөн энэ нь эцсийн өдөр байх болно гэдгийг би та нарт хэлье.

22 Мөн эдүгээ хайрт ах дүүс минь, би та нарыг Бурханы өмнө хүлээх үүргийн тань мэдрэмжинд сэрээж болохын тулд, та нар түүний өмнө

15a 2 Ниф. 4:18.
19a Мат. 3:3.
20a 1 Ниф. 10:19;
Алма 37:12;

С ба Г 3:2.
21a 1 Кор. 3:16–17; 6:19;
Мозая 2:37;
Алма 34:36.

б 1 Ниф. 15:33–35;
2 Ниф. 9:16;
Морм. 9:14;
С ба Г 88:35.

гэмгүйгээр алхаж болохын тулд, та нар хүлээн авсан түүнийхээ, та нар Бурханы ариун жаягийн дагуу алхаж болохын тулд би эдгээр зүйлийг та нарт хэлсэн бөлгөө.

23 Мөн эдүгээ би та нарыг “даруухан, мөн хүлцэнгүй бас эелдэг байгаасай хэмээнэ; харьцахад амархан; тэсвэр мөн тэвчээрээр дүүрэн; бүх зүйлд биеэ барьж ханддаг; Бурханы зарлигуудыг дагахдаа цаг үргэлж шаргуу; сүнсний бас биеийн аль алинд нь хэрэгцээтэй зүйлийг юуг боловч гуйдаг; өөрсдийн хүлээн авдаг зүйлүүдэд юуны төлөө боловч Бурханд талархлаа үргэлж эргэн мэдүүлдэг байгаасай хэмээнэ.

24 Мөн та нар “итгэл, найдвар мөн энэрлийг агуулж бай, тэгвэл та нар сайн үйлсээр үргэлж бялхах болно.

25 Мөн та нарын өмсгөлийг толбогүй байлгаж, мөн өөрсдийн тань өмсгөлүүд бүр тэдний өмсгөлүүд мэт “толбогүй учир, та нар эцсийн өдөр Абрахам, Исаак, мөн Иаков болон дэлхийн эхлэлээс байсан бүх ариун бошиглогчидтой хамт тэнгэрийн хаант улсад ахин гарахгүйгээр хамт суухаар хүргэгдэж болохын тулд Их Эзэн та нарыг адислаг.

26 Мөн эдүгээ хайрт ах дүүс минь, надад гэрчлэх Сүнсний дагуу би эдгээр үгсийг та нарт ярилаа; мөн миний үгэнд хандсан та нарын үлэмжийн

хичээнгүй байдал хийгээд анхаарлын учир бодгаль минь үлэмж баяснам.

27 Мөн эдүгээ, та нарын дээр, мөн танай гэр орон мөн газар нутгуудын дээр мөн та нарын бог бас бод мал, мөн та нарын эзэмшдэг бүхний дээр, та нарын эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийн тань дээр, та нарын итгэл хийгээд сайн үйлсийн дагуу, Бурханы “амар амгалан энэ цагаас хойш мөн үүрд оршиг. Мөн би ийн ярив. Амен.

БҮЛЭГ 8

Алма Мелект номлож мөн баптисм хүртээв—Тэрээр Аммонайха дахь тэднээр эсэргүүцэгдэж мөн орхин одов—Тэнгэр элч түүнд эргэн явж мөн уг хүмүүст наманчлалыг зарлахыг зарлиг болгов—Тэр Амюлекээр хүлээн авагдаж, мөн тэд хоёулаа Аммонайха дахь тэдэнд номлов. Ойролцоогоор мээ 82 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор бичигдэж чадахааргүй олон зүйлийг Гидеоны хүмүүст зааж, тэрээр Зарахемлагийн нутагт урьд нь хийснийхээ адилаар сүмийн журмыг тогтоосны дараа “Гидеоны нутгаас эргэж ирэв, тийм ээ, тэрээр өөрийн гүйцэтгэсэн хөдөлмөрөөс өөрийгөө амраахаар Зарахемла дахь гэртээ эргэж ирэв.

2 Мөн тийн Нифайн хүмүү-

23a су Даруу, Даруу байдал.

24a 1 Кор. 13:1–13;

Ифер 12:30–35;
Моро. 7:33–48.

25a 2 Петр 3:14.

27a су Амар амгалан.
8 1a Алма 2:20; 6:7.

сийн дээрх шүүгчдийн засаглалын ес дэх он төгсгөв.

3 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын аравдугаар оны эхлэлд, Алма тэндээс одож мөн баруун зүгт аглаг буйдын захад, “Сидон голын баруун тал дахь, Мелекийн нутаг тийш аянаа хөөв.

4 Мөн тэрээр өөрийн дуудагдсан байсан тэр Бурханы “ариун жаягийн дагуу Мелек нутаг дахь хүмүүст зааж эхлэв; мөн тэрээр Мелекийн бүх нутаг даяар хүмүүст зааж эхлэв.

5 Мөнхүү улиран тохиох дор аглаг буйдтай хиллэх нутгийн бүх хязгааруудаас хүмүүс түүн дээр ирэв. Мөн тэд бүх нутаг даяар баптисм хүртэв;

6 Түүнчлэн тэрээр Мелек дэх ажлаа дуусгаад тэндээс одож, мөн Мелек нутгийн умардыг зорин гурав хоног аялав; мөн тэр Аммонайха гэж нэрлэгдсэн хотод ирэв.

7 Эдүгээ өөрсдийн нутаг, мөн өөрсдийн хотууд, мөн өөрсдийн тосгод, тийм ээ, бүх жижиг тосгодоо ч анх тэдгээрийг эзэмшиж асан түүний нэрээр нэрлэх нь Нифайн хүмүүсийн заншил байв; мөн энэ нь Аммонайхагийн нутагт ч тийм байв.

8 Мөнхүү улиран тохиох дор Алма Аммонайхагийн хотод

ирээд тэрээр тэдэнд Бурханы үгийг номлож эхлэв.

9 Эдүгээ Аммонайхагийн хотын хүмүүсийн зүрх сэтгэлд Сатан агуу “суурь эзэлсэн байв; тиймийн тул тэд Алмагийн үгсийг дуулсан нь үгүй.

10 Гэсэн хэдий ч тэрээр Сүнсээ уг хотод байсан хүмүүсийн дээр юүлээсэй хэмээн Алма оюун санаагаар ихэд “ажиллаж, ⁶тэмцсэн; тэрээр түүнчлэн тэд наманчлалд баптисм хүртэж болохыг зөвшөөрөөсэй хэмээн “хүчит залбиралдаа Бурханы өмнө өөртэйгөө тэмцэлдсэн ажээ.

11 Гэсэн хэдий ч, тэд зүрх сэтгэлээ хатууруулж, түүнд хэлсэн нь: Болгоогтун, та бол Алма гэдгийг бид мэднэ; мөн та бол өөрийн уламжлалын дагуу уг нутгийн олон хэсгүүдэд өөрийн байгуулсан сүмийн дээрх дээд санваартан гэдгийг бид мэднэ; мөн бид танай сүмийнх бус, мөн бид тийм мунхаг уламжлалд итгэхгүй.

12 Мөн эдүгээ бид таны сүмийнх биш учраас та бидний дээр хүчгүйг тань бид мэднэ; мөн та шүүгчийн суудлыг “Нифайхад дамжуулан өгсөн; тиймийн тул та бидний дээрх ерөнхий шүүгч биш.

13 Эдүгээ хүмүүс үүнийг хэлж, мөн түүний бүх үгсийг эсэргүүцэж, мөн түүнийг доромжлон, мөн түүнийг дээр нулимж, мөн түүнийг

3а Алма 16:6–7.
4а С ба Г 107:2–4.
су Мелкизедек санваар.

9а 2 Ниф. 28:19–22;
С ба Г 10:20.
10а Алма 17:5.
б Инос 1:1–12.

в 3 Ниф. 27:1.
су Залбирал.
12а Алма 4:20.

хотоосоо зайлуулсны дараа, тэрээр тэндээс одож мөн Аарон гэж нэрлэгдсэн хотын зүг аянаа хөөв.

14 Мөнхүү улиран тохиох дор Аммонайхагийн хотод байсан хүмүүсийн ёс бусын учир их “бэрхшээл мөн сэтгэлийн тарчлалыг туулан, тэрээр харуусалдаа дарагдан цааш аялж явтал, улиран тохиох дор Алма тийн харуусалд дарагдан байтал, болгоогтун Их Эзэний нэгэн “тэнгэр элч түүнд үзэгдэж, өгүүлсэн нь:

15 Адислагдсан болой та, Алма; тиймийн тул, тэргүүнээ өргө мөн баясагтун, учир нь танд баясах агуу шалтгаан буй; тодруулбал та түүнээс анхныхаа зарыг хүлээн авсан тэр цагаас Бурханы зарлигуудыг дагахад итгэлтэй байсан болой. Болгоогтун, үүнийг танд “хүргэсэн нь би билээ.

16 Мөн болгоогтун, таныг Аммонайхагийн хотод эргэн очиж, мөн уг хотын хүмүүст дахин номло хэмээн танд зарлиглахаар илгээгдсэн болой би; тийм ээ, тэдэнд номлогтун. Тийм ээ, тэд наманчлахгүй аваас Их Эзэн Бурхан тэднийг “устгах болно гэдгийг тэдэнд хэлэгтүн.

17 Учир нь болгоогтун, тэд таны хүмүүсийн эрх чөлөөг устгаж болохын тулд тэд энэ цагт бодолхийлнэ, (учир нь Их Эзэн ийн хэлдэг) энэ нь түүний өөрийнхөө хүмүүст

өгсөн түүний тогтоолууд, мөн шүүлтүүд, мөн зарлигуудын эсрэг болох тэр болой.

18 Эдүгээ улиран тохиох дор Алма Их Эзэний тэнгэр элчээс түүний зарыг хүлээн авсныхаа дараа тэрээр Аммонайха нутгийн зүг хурдан эргэлээ. Мөн тэрээр уг хотод өөр нэг замаар, тийм ээ, Аммонайха хотын өмнөдөд байх замаар нэвтрэв бөлгөө.

19 Мөн тэрээр хотод орохдоо тэр өлсөж байв, мөн тэрээр нэгэн эрд хэлэв: Бурханы даруухан үйлчлэгчид та идэх юм өгөөч?

20 Мөн сайхь эр түүнд хэлэв: Би бол нифай үндэстнийх, мөн та бол Бурханы ариун бошиглогч гэдгийг би мэднэ, учир нь “тэнгэр элч: Та хүлээн авах болно хэмээн үзэгдлээр хэлсэн тэр хүн бол та болой. Тиймийн тул, надтай хамт гэрт минь оч мөн би тантай хүнсээ хуваая; мөн та надад болон миний гэрийнхэнд адислал байх болно.

21 Мөнхүү улиран тохиох дор мөнөөх хүн түүнийг гэртээ хүлээн авав; мөн тэр хүн “Амюлек хэмээх нэртэй байв; мөн тэрээр талх, мах авчирч мөн Алмагийн өмнө тавив.

22 Мөнхүү улиран тохиох дор Алма талхыг идэж цадав; мөн тэрээр Амюлекийг мөн түүний гэрийнхнийг “адислав, тэгээд тэрээр Бурханд талархал мэдүүлэв.

14a су Дайсан.
б Алма 10:7–10, 20.
су Тэнгэр элчүүд.

15a Мозая 27:11–16.
16a Алма 9:12, 18, 24.
20a Алма 10:7–9.

21a су Амюлек.
22a Алма 10:11.

23 Мөн тэр идэж мөн цадсаныхаа дараа Амюлект хэлсэн нь: Би бол Алма, мөн уг нутаг даяарх Бурханы сүмийн дээрх “дээд санваартан.

24 Мөн болгоогтун, би энэ бүх хүмүүсийн дунд, илчлэлт хийгээд бошиглолын суу билгийн дагуу, Бурханы үгийг номлохоор дуудагдсан; мөн би энэ нутагт байсан мөн тэд намайг хүлээж авахгүй байлаа, харин тэд намайг “хөөж тэгээд би үүрд энэ нутагт араа харуулах дөхөв.

25 Гэвч болгоогтун, би дахин эргэж мөн энэ хүмүүст, тийм ээ, мөн тэдний алдсуудын талаар тэдний эсрэг гэрчлэхээр бошиглох ёстой хэмээн зарлиглуулав.

26 Мөн эдүгээ, Амюлек, та намайг хооллож мөн оруулсан учир адислагдсан билээ та; учир нь би олон хоног мацаг барьснаас би өлссөн байв.

27 Мөн Алма хүмүүст номлож эхлэхийн өмнө тэрээр олон хоног Амюлектэй үлдэв.

28 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс алдсууддаа улам бүр лавширч байв.

29 Мөн үг Алмад ирж хэлрүүн: Явагтун; мөн түүнчлэн миний зарц Амюлект хэл, явж мөн энэ хүмүүст бошиглогтун, өгүүлсэн нь — “Наманчлагтун та нар, учир нь Их Эзэн ийн хэлнэ, та нар наманчлахгүй аваас би энэ хүмүүст уур хилэнгээрээ зочлох болно; тийм ээ, мөн би

догшин хилэнгээ холдуулах нь үгүй.

30 Мөн Алма, мөн түүнчлэн Амюлек, Бурханы үгсийг тэдэнд тунхаглахаар хүмүүсийн дунд одов; мөн тэд Ариун Сүнсээр дүүргэгдэв.

31 Мөн тэдэнд “хүч өгөгдсөн байв, үүний хэрээр тэд гянданд хоригдох нь боломжгүй болсон аж; бас хэн нэгэн тэднийг алах боломжгүй байсан аж; гэсэн хэдий ч тэд хүлэгдэж мөн шоронд хаягдах хүртлээ өөрсдийн “хүчийг хэрэглэсэнгүй. Эдүгээ, энэ нь Их Эзэн өөрийн хүчийг тэднээр үзүүлж болохын тулд хийгдсэн бөлгөө.

32 Мөнхүү улиран тохиох дор тэд одож мөн Их Эзэн тэдэнд өгсөн тэрхүү сүнс болоод хүчний дагуу хүмүүст номлож мөн бошиглож эхлэв.

Аммонайхагийн нутагт байсан хүмүүст тунхагласан, Алмагийн үгс, мөн түүнчлэн Амюлекийн үгс оршвой. Мөн түүнчлэн тэд шоронд хаягдаж, мөн тэдэнд байсан Бурханы тэрхүү гайхамшигт хүчээр чөлөөлөгдөв, Алмагийн цэдгийн дагуу оршвой.

9-өөс 14 дүгээр бүлэгт агуулагдав.

БҮЛЭГ 9

Аммонайхагийн хүмүүст наманчлахыг Алма зарлиглав—

23a Алма 5:3, 44, 49;
13:1–20.

24a Алма 8:13.

29a Алма 9:12, 18.
су Наманчлах,
Наманчлал.

31a 1 Ниф. 1:20.
б Алма 14:17–29.

Их Эзэн эцсийн өдрүүдэд леменчүүдэд нигүүлсэнгүй хандах болно—Хэрэв нифайчууд гэрлийг орхивол, тэд леменчүүдээр устгагдах болно—Бурханы Хүү удахгүй ирнэ—Тэрээр наманчилж, баптисм хүртэх, мөн өөрийнх нь нэрэнд итгэх тэднийг гэтэлгэх болно. Ойролцоогоор мээ 82 он.

Мөн үүнчлэн, Алма, би, Амюлекийг авч мөн явж мөн дахин энэ хүмүүст өөрөөр хэлбэл Аммонайхагийн хотод байсан хүмүүст номлохыг Бурханаас зарлиг болгуулаад, улиран тохиох дор намайг тэдэнд номлож эхлэхэд, тэд надтай ийн маргаж эхлэв, өгүүлсэн нь:

2 Та хэн билээ? Бид “нэг хүний гэрчлэлд, тэр ч байтугай тэрээр бидэнд дэлхий сөнөх болно хэмээн номлож байхад итгэнэ хэмээн та бодно уу?

3 Эдүгээ тэд өөрсдийн ярьсан үгсээ ойлгосон нь үгүй; учир нь тэд дэлхий сөнөх болно гэдгийг мэдсэнгүй.

4 Мөн тэд түүнчлэн хэлэв: Хэрэв та энэ агуу хот “нэг өдрийн дотор устгагдах болно хэмээн бошигловч бид таны үгсэд итгэхгүй.

5 Эдүгээ тэд Бурхан тийм гайхамшигт үйлүүдийг хийж чаддагийг мэдсэнгүй, учир нь тэд зүрх сэтгэл нь хатуу мөн зөрүүд хүмүүс байв.

6 Мөн тэд хэлэв: Энэ хүмүү-

сийн дунд тийм агуу хийгээд гайхамшигт зүйлүүдийн үнэнийг тэдэнд тунхаглуулахаар нэг хүнээс “илүүд эрх мэдэлтнийг үл илгээгч, Бурхан гэгч ⁶хэн бэ?

7 Мөн тэд надад гар хүрэхээр урагш дөхөв; гэвч болгоогтун, тэд тэгсэнгүй. Мөн би тэдэнд тунхаглахаар зоригтойгоор зогсов, тийм ээ, би тэдэнд зоригтойгоор гэрчилж хэлсэн нь:

8 Болгоогтун, Ай ёс бус мөн тэрс “үеийнхэн та нар, эцэг өвгөдийнхөө уламжлалыг та нар хэрхэн мартав; тийм ээ, та нар Бурханы зарлигуудыг хичнээн хурдан мартав аа.

9 Бидний өвөг болох Лихай, Бурханы “мутраар Иерусалимаас гарган авчрагдсаныг санахгүй байна уу? Та нар тэд бүгд аглаг буйд дундуур түүгээр удирдагдсаныг санахгүй байна уу та нар?

10 Мөн тэрээр хичнээн удаа бидний эцэг өвгөдийг дайснуудынх нь гараас чөлөөлж, мөн тэднийг бүр ах дүүсийнх нь гараар устгагдахаас хадгалан хамгаалсныг ийм хурдан мартсан гэж үү, та нар?

11 Тийм ээ, мөн хэрэв түүний зүйрлэшгүй хүч, мөн түүний нигүүлсэл, мөн бидэнд хандах түүний тэсвэр байгаагүй сэн бол, бид цагийн энэ үеэс хамаагүй урьд гарах аргагүйгээр газрын гадаргуу дээрээс арчигдах байсан, мөн “төгсгөлгүй зовлон мөн

9 2а Дэд хууль 17:6.
4а Алма 16:9–10.
6а Алма 10:12.

б Ег. 5:2; Мозая 11:27;
Моце 5:16.
8а Алма 10:17–25.

9а 1 Ниф. 2:1–7.
11а Мозая 16:11.

гаслангийн байдалд оноогдох нь болзошгүй ажгуу.

12 Болгоогтун, эдүгээ тэрээр наманчлахыг та нарт зарлиглаж байна хэмээн та нарт хэлж байна би; мөн та нар наманчлахгүй аваас та нар Бурханы хаант улсыг өвлөж чадах аргагүй болно. Гэвч болгоогтун, энэ нь бүгд биш — тэрээр та нарт наманчлахыг зарлигласан, эсвээс тэр та нарыг газрын гадаргуу дээрээс бүрмөсөн “устгах болно; тийм ээ, тэрээр та нарт уур хилэндээ зочлох болно, мөн ^бдогшин хилэндээ тэр холдож зайлахгүй байх болно.

13 Болгоогтун, тэрээр Лихайд ярьж, хэлсэн нь: Та нар миний зарлигуудыг “дагахын хэрээр, та нар уг нутагт дэгжих болно гэсэн үгсийг санахгүй байна уу? Мөн үүнчлэн: Та нар миний зарлигуудыг дагахгүй байхын хэрээр та нар Их Эзэний дэргэдээс тусгаарлагдах болно гэсэн үг байдаг билээ.

14 Эдүгээ леменчүүд Бурханы зарлигуудыг дагаагүйн хэрээр, тэд Их Эзэний дэргэдээс “тусгаарлагдсаныг та нар санаасай хэмээнэ би. Эдүгээ Их Эзэний үг энэ зүйлд нотлогдож, мөн леменчүүд уг нутаг дахь зөрчлүүдийнхээ эхлэлээс л түүний дэргэдээс тусгаарлагдсаныг бид харж байна.

15 Гэсэн хэдий ч би та нарт хэлнэ, хэрэв та нар нүглүүддээ үлдвэл шүүлтийн өдөр тэд та нараас илүү “тэвчиж болмоор байх болно, тийм ээ, мөн та нар наманчлахаас бусдаар бол, бүр энэ амьдралд ч тэд та нараас илүү тэвчиж болмоор байх болно.

16 Учир нь; тэднийг “үл мэдэх байдалд байлгадаг тэдний эцэг өвгөдийнх нь ^буламжлалуудын учир леменчүүдэд “зориулагдсан олон амлалт байдаг; тиймийн тул Их Эзэн тэдэнд нигүүлсэнгүй хандаж мөн уг нутагт оршихыг нь ‘уртасгах болно.

17 Мөн эцэг өвгөдийнх уламжлалууд нь зөв бус гэдгийг мэдэхийн тулд, тэд түүний үгсэд итгүүлэхээр хэзээ нэгэн цагт “авчрагдана; мөн тэдний олон нь аврагдах болно, учир нь Их Эзэн өөрийнх нь нэрийг ^бдуудах тэд бүгдэд нигүүлсэнгүй хандах болно.

18 Гэвч болгоогтун, хэрэв та нар ёс бус байдалдаа хэвээр үлдвэл энэ нутаг дахь та нарын өдрүүд уртасгагдах нь үгүй гэдгийг би та нарт хэлнэ, учир нь “леменчүүд та нарын дээр илгээгдэх болно; мөн хэрэв та нар наманчлахгүй аваас тэд та нарын мэдээгүй үед чинь ирэх болно, мөн та нар ^ббүрмөсөн

12a Алма 8:16; 10:19, 23, 27.

б Алма 8:29.

13a 2 Ниф. 1:20; Мозая 1:7; Алма 37:13.

14a 2 Ниф. 5:20–24; Алма 38:1.

15a Мат. 11:22, 24.

16a Мозая 3:11.

б Мозая 18:11–17. в Алма 17:15.

г Хил. 15:10–12.

17a Инос 1:13.

б Алма 38:5;

С ба Г 3:8.

18a Алма 16:2–3.

б Алма 16:9.

устгагдах устгалаар зочлогдох болно; мөн энэ нь Их Эзэний догшин “хилэнгийн дагуу байх болно.

19 Учир нь өөрийнх нь хүмүүсийг устгахыг, та нарыг алдастаа амьдрахыг тэр үл тэвих болно. Би та нарт хэлнэ, Үгүй; хэрэв тийм их гэрэл мөн тийм их мэдлэг Их Эзэн Бурханаас нь тэдэнд өгөгдсөний дараа, тэд нүгэлд мөн зөрчилд “унах нь боломжтой аваас, тэрээр Нифайн хүмүүс гэж нэрлэгдсэн өөрийнх нь бүх хүмүүсийг леменчүүд ^бустгахыг тэвчих нь дээр гэж үзэх болно;

20 Тийм ээ, Их Эзэний маш ихээр таалсан хүмүүс байсны дараа; тийм ээ, бусад бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүсээс илүүтэйгээр таалсны дараа; тэдний хүсэл, мөн тэдний итгэл, мөн залбирлуудынх нь дагуу байсан, байгаа, мөн байх тэдгээр бүх зүйл тэдэнд “мэдүүлэгдсэний дараа буюу;

21 Бурханы Сүнсээр зочлогдсоны; тэнгэр элчүүдтэй ярилцаж, мөн Их Эзэний дуу хоолой өөрсдөд нь ярьсны дараа; мөн бошиглолын суу билэг, мөн илчлэлтийн суу билэг, мөн түүнчлэн олон бэлэг, хэл хэлээр ярих бэлэг, номлох бэлэг, мөн Ариун Сүнсний бэлэг, мөн “орчуулгын бэлгийг авсны дараа буюу;

22 Тийм ээ, Бурханаар Иерусалимын нутгаас Их Эзэний мутраар гаргагдан “чөлөөлөгдсөний дараа; өлсгөлөнгөөс, мөн өвчнүүдээс, мөн бүх төрлийн зүйл бүрийн эмгэгүүдээс аврагдсаны дараа; мөн тэд устгагдаж болохгүйн учир, тулаанд хүчтэй болсны дараа; цагаас цагт ^бдарангуйллаас гарган авчрагдаж, мөн эдүгээг хүртэл хамгаалагдаж мөн хадгалагдсаны дараа; мөн тэд бүх төрлийн зүйлүүдээр баян болтлоо дэгжээгдсэний дараа—

23 Мөн эдүгээ болгоогтун би та нарт хэлнэ, хэрэв ийм олон адислалыг Их Эзэний мутраас хүлээн авсан энэ хүмүүс, тэдэнд байх гэрэл мөн мэдлэгийн эсрэг зөрчил үйлдэх аваас, би та нарт хэлнэ хэрэв энэ байдал тохиовол, хэрэв тэд зөрчилд унах аваас, тэднийг бодвол леменчүүд хамаагүй илүү “хүлцэж болохуйц байх болно.

24 Учир нь болгоогтун, Их Эзэний “амлалтууд леменчүүдэд зориулагдсан юм, гэвч хэрэв та нар зөрчил үйлдвэл тэдгээр нь та нарт хүртээлгүй; учир нь хэрэв та нар түүнийг эсэргүүцвэл та нар газрын гадаргуу дээрээс бүрмөсөн устгагдах болно хэмээн Их Эзэн тодорхойгоор амлаж мөн чандлан тогтоосон бус уу?

25 Мөн эдүгээ та нар устгаг-

18в Алма 8:29.

19а Алма 24:30.

б 1 Ниф. 12:15, 19–20;

Алма 45:10–14.

20а су Илчлэлт.

21а Омнай 1:20;

Мозая 8:13–19;

28:11–17.

22а 2 Ниф. 1:4.

б Мозая 27:16.

23а Мат. 11:22–24.

24а 2 Ниф. 30:4–6;

С ба Г 3:20.

дахгүй байж болох энэхүү шалтгааны учир, Их Эзэн өөрийн хүмүүсээс олонд нь тэнгэр элчээ зочлуулахаар мөн ийн тунхаглуулахаар илгээсэн ажгуу; тэд явж мөн энэ хүмүүст хүчтэйгээр ийн хашгирах ёстой хэмээн, өгүүлсэн нь: “Наманчлагтун та нар, учир нь тэнгэрийн хаант улс ойрхон байна;

26 Мөн үүнээс “олон бус өдрийн дараа Бурханы Хүү алдар суундаа ирэх болно; мөн түүний алдар суу ач ивээл, тэгш эрх, мөн үнэнээр дүүрэн, тэвчээр, ^бнигүүлсэл, мөн тэсвэрээр дүүрэн, өөрийн хүмүүсийн гуйлтыг ^ссонсохдоо мөн тэдний залбирлуудыг хариулахдаа түргэн, Эцэгийн ^тТөрсөн Ганцын ^аалдар суу байх болно.

27 Мөн болгоогтун, тэрээр түүний нэрэнд итгэлтэйн дагуу наманчлалд “баптисм хүртэх тэднийг ^бгэтэлгэхээр ирэх болно.

28 Тиймийн тул, та нар Их Эзэний замыг бэлтгэцгээ, учир нь бүх хүмүүн өөрсдийн “ажлын шагналыг хадан авах тэр цаг ойрхон байна, тэдгээр нь ямар байсны дагуу — хэрэв тэдгээр нь зөв шударга байсан бол тэд Есүс Христийн хүч мөн чөлөөлөлтийн дагуу, бодгальдаа авралыг ^бхадан

авах болно; мөн хэрэв тэдгээр нь хилэнцэт байсан бол тэд чөтгөрийн хүч мөн боолчлолын дагуу, бодгальдаа “ялыг хадан авах болно.

29 Эдүгээ болгоогтун, энэ бол хүмүүст хашгирах тэнгэр элчийн дуу хоолой билээ.

30 Мөн эдүгээ, “хайрт ах дүүс минь, учир нь та нар миний ах дүүс, мөн та нар хайрлагдвал зохино, мөн та нар наманчлалд нийцэх тэр үйлүүдийг авчирвал зохино, яагаад гэвэл та нарын зүрх сэтгэл Бурханы үгийн эсрэг дэндүү хатуурсан байв, мөн та нар ^бтөөрөлдсөн мөн унасан хүмүүс байсны учир болой.

31 Эдүгээ улиран тохиох дор би, Алма, эдгээр үгсийг ярихад, болгоогтун, хүмүүс надад хилэгнэж байсны учир би өөрсдөд нь тэд бол хатуу зүрх сэтгэлтэй мөн “зөрүүд хүмүүс байсан хэмээн хэлсэн бөлгөө.

32 Мөн түүнчлэн би тэдэнд тэд бол төөрөлдсөн мөн унасан хүмүүс байсныг хэлсэн учир тэд надад уурлаж, мөн тэд намайг шоронд хаяж болохын тулд тэд надад гар хүрэхийг завдав.

33 Гэвч улиран тохиох дор Их Эзэн тэдэнд тэр цагт намайг барьж мөн намайг шоронд хийхийг зөвшөөрсөнгүй.

25a Алма 7:9; Хил. 5:32.

26a Алма 7:7.

б су Нигүүлсэнгүй, Нигүүлсэл.

в Дэд хууль 26:7.

г су Төрсөн Ганц.

д су Ач ивээл.

27a су Гэтэлгэх,

Гэтэлгэгдэх,

Гэтэлгэл.

б су Баптисм,

Баптисм хүртээх.

28a С ба Г 1:10; 6:33.

б Дуул. 7:16.

в су Ял.

30a 1 Иохан 4:11.

б Алма 12:22.

31a 2 Ниф. 25:28;

Мозая 3:14.

34 Мөнхүү улиран тохиох дор Амюлек явж мөн урагшлан зогсож, мөн түүнчлэн тэдэнд номлож эхлэв. Мөн эдүгээ Амюлекийн “үгс бүгд бичигдсэнгүй, гэсэн хэдий ч түүний үгсийн нэг хэсэг нь энэ номонд бичиглэгдсэн ажгуу.

БҮЛЭГ 10

Лихай Манассегаас гаралтай — Алмаг халамжил гэсэн тэнгэр элчийн зарлигийг Амюлек давтан хэлж өгөв — Зөв шударгыг үйлдэгсдийн залбирлууд хүмүүсийг хэлтрүүлэгдэхээр болгодог — Зөв шударга бус хуульчид мөн шүүгчид хүмүүсийн устгалын суурийг тавьдаг. Ойролцоогоор мэв 82 он.

Эдүгээ Аммонайхагийн нутагт байсан хүмүүст “Амюлекийн номлосон тэр ⁶үгс нь эдгээр болой, хэлсэн нь:

2 Би бол Амюлек; би бол Аминадайн удам болох тэр Ишмэилийн хүү асан Гиддонахын хүү билээ; мөн энэ ариун сүмийн ханан дээр Бурханы хуруугаар бичигдсэн бичгийг хөрвүүлсэн мөнхүү тэр Аминадай бөлгөө.

3 Мөн Аминадай нь ах нарынхаа гараар Египетэд “худалдагдсан ⁶Иосефын хүү асан, ⁶Манассегийн удам болох Иерусалимын нутгаас

гарч ирсэн Лихайн хүү Нифайн үр удам билээ.

4 Мөн болгоогтун, түүнчлэн намайг мэддэг тэр бүгдийн дунд би нэр хүндээр багагүй хүн; тийм ээ, мөн болгоогтун, би олон садан төрөл мөн “найзуудтай, мөн түүнчлэн би өөрийн гарын хөдөлмөрөөр их баялаг олж авсан билээ.

5 Гэсэн хэдий ч, энэ бүгдийн эцэст, би Их Эзэний замууд мөн түүний “нууцууд мөн гайхамшигт хүчний тухайд ихийг хэзээ ч мэдэж байсангүй. Би эдгээр зүйлүүдийн тухайд ихийг хэзээ ч мэдэж байгаагүйгээ хэлсэн; гэвч болгоогтун, би алджээ, учир нь би түүний нууцууд мөн түүний гайхамшигт хүчнээс; тийм ээ, бүр энэ хүмүүсийн амьдралыг хамгаалах хамгаалалтанд ихийг үзсэн.

6 Гэсэн хэдий ч, би зүрх сэтгэлээ хатууруулсан, учир нь би олон удаа “дуудагдсан боловч би ⁶сонсохоос татгалзсан; тиймийн тул би эдгээр зүйлүүдийн талаар мэдэж байсан боловч мэдэхийг хүссэнгүй; тиймийн тул бүр шүүгчдийн засаглалын аравдугаар оны энэхүү долдугаар сарын дөрөв дэх өдрийг хүртэл би зүрх сэтгэлийхээ ёс бусаар Бурханыг эсэргүүцсээр байсан билээ.

7 Би ойрын садантайгаа уул-

34a Алма 10.
10 1a Алма 8:21–29.
б Алма 9:34.
3a Эхл. 37:29–36.
б су Иосеф, Иаковын

хүү.
в Эхл. 41:51;
Шаст. дээд 9:3.
4a Алма 15:16.
5a су Бурханы

нууцууд.
6a Алма 5:37.
б С ба Г 39:9.

захаар явж байтал, болгоогтун, Их Эзэний “тэнгэр элч надад үзэгдэж мөн хэлэв: Амюлек, гэртээ эргэж харь, учир нь та Их Эзэний бошиглогчийг хооллох болно; тийм ээ, Бурханаас сонгогдсон хүн болох тэр ариун хүнийг; учир нь тэр энэ хүмүүсийн нүглүүдийн учир олон өдөр “мацаг барьсан, мөн тэрээр өлссөн, мөн та түүнийг гэртээ “хүлээн авч мөн түүнийг хооллох болно, мөн тэр таныг мөн гэрийнхнийг тань адислах болно; мөн Их Эзэний адислал таны болон танай гэрийнхний дээр байх болно.

8 Мөнхүү улиран тохиох дор би тэнгэр элчийн дуу хоолойг дагаж, мөн гэрийнхээ зүг эргэв. Мөн би тийш явж байтал тэнгэр элчийн надад: Та гэртээ хүлээн авах болно гэж хэлсэн тэр “хүнийг би олсон — мөн болгоогтун тэр нь Бурханы зүйлүүдийн талаар та нарт ярьж байсан мөнхүү тэр хүн билээ.

9 Мөн тэр бол ариун хүн гэдгийг тэнгэр элч надад хэлсэн; иймийн тул тэр бол “ариун хүн гэдгийг би мэднэ, яагаад гэвэл энэ нь Бурханы тэнгэр элчээр хэлэгдсэн болой.

10 Мөн үүнчлэн, түүний гэрчилсэн зүйлүүд үнэн гэдгийг би мэднэ; учир нь болгоогтун би та нарт хэлнэ, Их Эзэн амьдын адил, үүнчлэн тэрээр өөрийн “тэнгэр элчийг эдгээр

зүйлийг надад мэдүүлэхээр илгээсэн юм; мөн энэ Алмаг миний гэрт “амьдарч байх зуур тэрээр үүнийг хийсэн ажгуу.

11 Учир нь болгоогтун, тэрээр миний гэрийнхнийг “адисалсан, тэр намайг адисалсан, мөн миний эмэгтэйчүүдийг, мөн хүүхдүүдийг минь, мөн миний эцэг хийгээд төрөл төрөгсдийг минь, тийм ээ, бүр миний бүх төрөл садангуудыг тэрээр адисалсан билээ, мөн Их Эзэний адислал түүний ярьсан үгсийн дагуу бидэн дээр байв.

12 Мөн эдүгээ, Амюлек эдгээр үгсийг ярихад хүмүүс гайхширч эхлэв, тэдний буруутгагдаж байсан тэр зүйлийг, мөн түүнчлэн ирэх тэр зүйлийг, өөрсдөд нь байсан тэрхүү бошиглолын суу билгийн дагуу гэрчилсэн нэгэн гэрчээс “илүү нэгэн байсны учир болой.

13 Гэсэн хэдий ч, өөрсдийн башир “аргуудаар үгээр нь тэднийг буруутгаж болох тул, тэд тэдний эсрэг гэрчийг олж болохын тулд, тэд хуулийн дагуу шүүгдэж болохын тулд шүүгчдэдээ тэднийг шилжүүлж болохын тул, мөн өөрсдийн илрүүлэх эсвээс гэрчлэх тэр гэмт хэргийн дагуу, тэд алагдаж эсвээс шоронд хаягдаж болохын тулд тэднийг шалгаахыг бодсон зарим нь тэдний дунд байв.

7а Алма 8:20.

б Алма 5:4б; 6:6.

сү Мацаг барих,
Мацаг барилт.

в Үйлс 10:30–35.

8а Алма 8:19–21.

9а сү Ариун.

10а Алма 11:30–31.

б Алма 8:27.

11а Алма 8:22.

12а Алма 9:6.

13а Алма 11:21.

14 Эдүгээ энэ нь тэднийг устгахыг эрэлхийлсэн, хуульчид болох тэр, “шүүгчдийн өмнө хүмүүсийн гэмт хэргүүдийг шүүх хурал дээр эсвээс шүүх хурлын үеэр хуулийг хэрэгжүүлэхээр хүмүүсээр томилогдсон эсвээс хөлслөгдсөн, тэдгээр хүмүүс байсан бөлгөө.

15 Эдүгээ эдгээр хуульчид хүмүүсийн бүх башир арга мөн чадваруудад суралцсан байв; мөн энэ нь мэргэжилдээ чадамгай байж болох тэрхүү боломжийг олгохын тулд тэдэнд байсан болой.

16 Мөнхүү улиран тохиох дор тэд, ингэснээрээ тэд түүний өөрийнх нь үгсийг зөрөлдүүлэх буюу түүний ярих үгсийг няцааж болохын тулд Амюлекийг шалгааж эхлэв.

17 Эдүгээ тэд Амюлек өөрсдийнх нь төлөвлөгөөний тухайд мэдэж чадна гэдгийг тэд мэдсэнгүй. Гэвч улиран тохиох дор тэд түүнийг шалгааж эхлэхэд, тэрээр тэдний бодлыг “ойлгож, мөн тэр тэдэнд хэлэв: Ай ёс бус хийгээд тэрс⁶ үеийнхэн та нар, хуульчид мөн хоёр нүүртнүүд та нар, учир нь та нар чөтгөрийн суурийг тавьж байна; учир нь та нар Бурханы ариун хүмүүс болох тэднийг барих хавх хийгээд “занга тавьж байна.

18 Та нар зөв шударгын

замуудыг “гажуудуулах мөн Бурханы хилэнг толгой дээрээ доош авчрах, бүр энэ хүмүүсийг бүрмөсөн устгалд хүргэх төлөвлөгөөнүүдийг зэхэж байна.

19 Тийм ээ, бидний сүүлчийн хаан асан Мозая зөвөөр хэлсэн, тэрээр хаант улсыг өгөх гэж байх үедээ үүнийг шилжүүлэн өгөх хэн ч үгүй байснаас, энэ хүмүүс өөрсдийн саналаар засаглагдахаар болгоод — тийм ээ, хэрэв энэ хүмүүсийн санал алдсыг “сонгох тэр цаг ирэх аваас, тодруулбал, хэрэв энэ хүмүүс зөрчилд унах тэр цаг ирвэл, тэд устгалд бэлэн болон боловсорч гүйцсэн байна хэмээн тэрбээр зөвийг хэлсэн авай.

20 Мөн эдүгээ Их Эзэн та нарын алдсуудыг зөвөөр шүүдгийг би та нарт хэлнэ; тэрээр энэ хүмүүст “тэнгэр элчийнхээ дуу хоолойгоор: Наманчлагтун та нар, наманчил, учир нь тэнгэрийн хаант улс ойрхон байна хэмээн зөвөөр хашгирсан болой.

21 Тийм ээ, тэнгэр элчүүдийнхээ дуу хоолойгоор тэрээр зөвөөр хашгирдаг; би мутартаа тэгш эрх мөн шударга ёсыг барин өөрийн хүмүүсийн дунд “доошлон ирэх болно хэмээсэн ажгуу.

22 Тийм ээ, мөн хэрэв энэ нутагт одоо байгаа “зөв шударгыг үйлдэгчдийн залбир-

14a Алма 10:24; 11:20–21; 14:18.

17a Алма 12:3; 20:18, 32; С ба Г 6:16.

б Мат. 3:7; Алма 9:8.

в С ба Г 10:21–27.

18a Үйлс 13:10.

19a Мозая 29:27;

Алма 2:3–7;

Хил. 5:2.

20a Алма 8:14–16; 13:22.

21a Мозая 13:34.

22a Иаков 5:16;

Мозая 27:14–16.

лууд үгүйсэн бол, та нар бүр одоо ч бүрмөсөн сүйрэх устгалаар зочлогдох байсныг би та нарт хэлнэ; гэвч энэ нь Ноагийн өдрүүдэд хүмүүст ирсэн шиг ⁶үерээр байх нь үгүй, харин энэ нь өлсгөлөнгөөр мөн тахлаар мөн илдээр байх болно.

23 Гэвч та нар хэлтрүүлэгдэхийн учир нь зөв шударгыг үйлдэгчдийг “залбирлуудаар буюу; эдүгээ тиймийн тул, хэрэв та нар өөрсдийнхөө дундаас зөв шударгыг үйлдэгчдийг зайлуулах аваас Их Эзэн мутраа хумхиад суухгүй; харин тэрээр догшин хилэндээ тэр та нарын эсрэг гарч ирэх болно; тэгээд та нар өлсгөлөнгөөр, мөн тахлаар, мөн илдээр цохигдох болно; мөн та нар наманчлахгүй аваас тэр ⁶цаг удахгүй, дөхөж байна.

24 Мөн эдүгээ улиран тохиох дор хүмүүс Амюлект улам уурлаж, мөн тэд хашгиралдаж, өгүүлсэн нь: Энэ хүн бидний шударга хуулиудыг мөн бидний сонгосон цэцэн шүүгчдийг эсэргүүцэн доромжилж байна.

25 Гэвч Амюлек гараа урагш сунган, мөн тэдэнд илүү хүчтэйгээр хашгирч, хэлсэн нь: Ай ёс бус хийгээд тэрс үеийнхэн та нар, Сатан та нарын зүрх сэтгэлд яагаад ийм их байрыг эзлэв? Яригдсан үгсийг үнэний нь дагуу та

нарт ойлгуулахгүй байхын тулд, тэрээр та нарын дээр нүдийг чинь “харалган болгохоор хүчтэй байж болохын тулд та нар өөрсдөө яагаад түүнд бууж өгөв?

26 Учир нь болгоогтун, би та нарын хуулийн эсрэг гэрчилсэн гэж үү? Та нар эс ойлгоно; намайг хуулийн чинь эсрэг ярьсан гэж та нар хэлнэ; гэвч би тэгсэнгүй; харин би хуулийн чинь төлөө, та нарын буруушаалтын тулд ярьсан билээ.

27 Мөн эдүгээ болгоогтун, энэ хүмүүсийн устгалын суурь нь танай “хуульчид мөн шүүгчдийн зөв шударга бус байдлаар тавигдаж эхэлж байна гэдгийг би та нарт хэлнэ.

28 Мөн Эдүгээ улиран тохиох дор Амюлек эдгээр үгсийг ярихад хүмүүс түүний эсрэг хашгиралдаж, өгүүлсэн нь: эдүгээ бид энэ хүн чөтгөрийн хүүхэд гэдгийг мэдлээ, учир нь тэр бидэнд “худал хэллээ; учир нь тэр бидний хуулийн эсрэг ярилаа. Мөн эдүгээ тэр үүний эсрэг яриагүй хэмээн хэлж байна.

29 Мөн үүнчлэн, тэрээр бидний хуульчдын мөн бидний шүүгчдийн эсрэг доромжлов.

30 Мөн улиран тохиох дор эдгээр зүйлийг түүний эсрэг тэд санахын тулд хуульчид үүнийг зүрх сэтгэлдээ хадгалсан ажгуу.

226 Эхл. 8:21;
3 Ниф. 22:8–10.
су Ноагийн үеийн
Үер.

23а су Залбирал.
б Алма 34:32–35.
25а 2 Кор. 4:4;
Алма 14:6.

27а Лук 11:45–52.
28а Алма 14:2.

31 Мөн тэдний дунд Зиезром гэж нэрлэгдсэн нэгэн байв. Эдүгээ тэр нь Амюлек болон Алмаг “буруутгах тэдний дунд хамгийн нөлөө бүхий нэгэн байв; тэрээр хүмүүсийн дунд их хэргийг хийдэг байсан учир тэдний дундаас хамгийн мэргэжсэн нэгэн байв.

32 Эдүгээ эдгээр хуульчдын эрмэлзэл нь хөрөнгөжих явдал байв; мөн тэд ажлынхаа дагуу хөрөнгөжсөн ажээ.

БҮЛЭГ 11

Нифайчуудын мөнгөний тогтолцоо тайлбарлагдав — Амюлек Зиезромтой маргалдав — Христ нүгэлдээ буй хүмүүсийг аврахгүй — Зөвхөн тэнгэрийн хаант улсыг өвлөх тэд л аврагддаг — Бүх хүмүүн үхэшгүй амьдралд босох болно — Амилуулалтын дараа үхэл гэж үгүй. Ойролцоогоор мээ 82 он.

Эдүгээ Мозаягийн хуулинд, хуулийн шүүгч байсан хүн бүр өөрөөр хэлбэл шүүгчид байхаар томилогдсон тэд өөрсдийнх нь өмнө шүүгдэхээр авчрагдсан тэднийг шүүхээр хөдөлмөрлөсөн тэр цагийнхаа дагуу хөлс авах ёстой хэмээсэн байлаа.

2 Эдүгээ хэрэв хүн өөр нэгэнд өртэй, мөн тэр тавьсан өрөө төлөхгүй бол, тэрээр шүүгчид мэдүүлэгддэг байв; мөн шүүгч эрх мэдлээ ашиглан үйлдэж, мөн уг хүнийг

өөрийн өмнө авчруулахаар албан тушаалтныг илгээдэг байв; мөн тэрээр уг хүнийг хуулийн, мөн түүний эсрэг өгсөн мэдүүлгийн дагуу шүүж, мөн тийн уг хүн тавьсан өрөө төлөхөөр албадагдаж, эсвээс хөрөнгөнөөсөө хураалгаж, эсвээс хулгайч мөн дээрэмчний адил хүмүүсийн дундаас зайлуулагддаг байсан ажгуу.

3 Мөн шүүгч цагийнхаа дагуу өөрийн хөлсийг авдаг — өдөрт нэг алтан синайн, эсвэл алтан синаинтай тэнцэх, мөнгөн сенамыг буюу; мөн энэ нь өгөгдсөн хуулийн дагуу бөлгөө.

4 Эдүгээ эдгээр нь үнэ цэнийн нь дагуу алтны болон мөнгөнийх нь ялгаатай хэсгүүдийн нэрс буюу. Мөн уг нэрс нифайчуудаар өгөгджээ, учир нь тэд Иерусалимд байсан иудейчүүдийн маягаар тооцоолдоггүй байсан аж; бас иудейчүүдийн маягаар хэмждэг ч үгүй байв; харин шүүгчдийн засаглалыг хүртэл үе болгонд, тэд хүмүүсийн бодол мөн нөхцөлийн дагуу, өөрсдийн өртөг болоод өөрсдийн хэмжүүрийг өөрчилж байжээ, мөн эдгээр нь хаан Мозаягаар “тогтоогдсон буюу.

5 Эдүгээ тооцоолох нь ийм буюу — алтан синайн, алтан сион, алтан шаам, алтан лимна.

6 Мөнгөн синам, мөнгөн амнор, мөнгөн эзром, мөн мөнгөн онтай.

7 Нэг мөнгөн синам нь нэг алтан синайнтай тэнцэж, мөн аль аль нь нэг тогоо арвайг хэмжихийн тулд, мөн түүнчлэн бүх төрлийн нэг тогоо будаатай тэнцэж байв.

8 Эдүгээ нэг алтан сион нь хоёр синайны дайтай байв.

9 Мөн нэг алтан шаам нь хоёр сионы дайтай байв.

10 Мөн нэг алтан лимна нь тэднийг бүгдийг нэгтгэсний дайтай байв.

11 Мөн нэг мөнгөн амнор нь хоёр синамтай дүйцэхүйц их байв.

12 Мөн нэг мөнгөн эзром нь дөрвөн синамтай дүйцэхүйц их байв.

13 Мөн нэг онтай нь тэднийг бүгдийг нэгтгэсэнтэй дүйцэхүйц их байв.

14 Эдүгээ энэ нь тэдний өртгийг тооцоолох бага нэгжүүд—

15 Нэг шиблон нь хагас синам; тиймийн тул, нэг шиблон нь тогоо арвайн хагас нь.

16 Мөн нэг шиблам нь хагас шиблон болно.

17 Мөн нэг лий нь хагас шиблам болно.

18 Эдүгээ энэ нь тэдний тооцооны дагуух нэгж нь болой.

19 Эдүгээ нэг алтан антион нь гурван шиблонтой тэнцэнэ.

20 Эдүгээ энэ нь хөрөнгө хураах цорын ганц зорилгын төлөө байв, яагаад гэвэл тэд ажилласныхаа дагуу хөлсөө авдаг, тиймийн тул, тэд өөрс-

дөө илүү их ажилтай байж, тэдний өмнө авчрагдсан шүүх үйл ажиллагааны дагуу мөнгө “олж болохын тулд тэд хүмүүсийг үймээнд, мөн бүх төрлийн дураараа авирлах явдалд мөн ёс бусад өдөөн хатгадаг байлаа; тиймийн тул тэд хүмүүсийг Алма Амюлек нарын эсрэг өдөөн хатгав.

21 Мөн энэ Зиезром Амюлекийг шалгааж эхлэв, өгүүлсэн нь: Та нар өөрсдөөс чинь миний асуух хэдэн асуултанд хариулаач? Эдүгээ Зиезром зөв сайн болох түүнийг устгаж болохын тулд чөтгөрийн “аргуудад мэргэжсэн хүн байв; тиймийн тул, тэрээр Амюлект: Та нар өөрсдөд чинь миний тавих асуултуудад хариулна уу? хэмээв.

22 Мөн Амюлек түүнд хэлэв: Тийм ээ, хэрэв энэ нь надад орших Их Эзэний “Сүнсний дагуу байх аваас; учир нь би Их Эзэний Сүнсний эсрэг юу ч хэлэхгүй. Мөн Зиезром түүнд хэлсэн нь: Болгоогтун, энд зургаан мөнгөн онтай байна, мөн хэрэв та Эрхэм Агуу Нэгэний оршин буйг үгүйсгэх аваас би энэ бүгдийг танд өгөх болно.

23 Эдүгээ Амюлек хэлэв: Ай тамын “хүүхэд чи, юуны учир намайг ^буруу татнав? Зөв шударгыг үйлдэгсэд ямар ч иймэрхүү уруу таталтанд бууж өгдөггүйг чи мэдэх үү?

24 Бурхан үгүй гэдэгт чи итгэнэ үү? Би чамд хэлнэ, Үгүй,

20a Алма 10:32.

21a Алма 10:13.

22a су Ариун Сүнс.

23a Алма 5:41.

б су Уруу татах, Уруу таталт.

Бурхан бийг чи мэднэ, харин чи “ашиг орлогыг түүнээс илүүгээр хайрладаг ажээ.

25 Мөн эдүгээ чи Бурханы өмнө надад худал хэллээ. Хэдийгээр зүрх сэтгэлдээ үүнийг надад өгөлгүй өөртөө үлдээхээр байлаач—энэ их үнэ болох зургаан онтайг болгоогтун, би танд өгөх болно—хэмээн та на дад хэллээ. Мөн чи намайг устгах шалтаг олж болохын тулд би үнэн бөгөөд амьд Бурханыг үгүйсгэх нь чиний цорын ганц хүсэл байсан. Мөн эдүгээ болгоогтун, энэхүү их хилэнцийн төлөө чи шангаа хүртэх болно.

26 Мөн Зиезром түүнд хэлэв: Үнэн бөгөөд амьд Бурхан байдаг гэж та хэлэв үү?

27 Мөн Амюлек хэлэв: Тийм ээ, үнэн бөгөөд амьд Бурхан байдаг.

28 Эдүгээ Зиезром хэлсэн нь: Нэгээс илүү Бурхан байдаг уу?

29 Мөн тэр, Үгүй гэж хариулав.

30 Эдүгээ Зиезром түүнд тэрчлэн хэлсэн нь: Та эдгээр зүйлийг яаж мэдэв?

31 Мөн тэр хэлсэн нь: Нэгэн “тэнгэр элч надад эдгээрийг мэдүүлсэн билээ.

32 Мөн Зиезром үүнчлэн хэлэв: Ирэх тэр нь хэн билээ? Тэр нь Бурханы Хүү мөн үү?

33 Мөн тэрээр түүнд, Тийм хэмээн хэлэв.

34 Мөн Зиезром түүнд үүнчлэн хэлсэн нь: Тэрээр “нүгэл-

дээ буй өөрийн хүмүүсийг аврах уу? Мөн Амюлек хариулж мөн түүнд хэлэв: Би танд хэлнэ, тэр тэгэхгүй, учир нь өөрийн үгийг үгүйсгэх нь түүнд боломжгүй бөлгөө.

35 Эдүгээ Зиезром хүмүүст хэлсэн нь: Та нар эдгээр зүйлийг санахаа мэд; учир нь тэрээр цорын ганц Бурхан буй гэж хэлэв; гэсэн ч тэр Бурханы Хүү ирэх болно, харин Бурханд зарлиглах эрх мэдэл түүнд буй мэтээр тэр өөрийн хүмүүсийг аврахгүй хэмээв—

36 Эдүгээ Амюлек тэрчлэн түүнд хэлэв: Болгоогтун та худал хэлэв, учир нь та намайг Бурханд зарлиглах эрх мэдэлтэй мэтээр ярьсан хэмээн хэлж байна, би нүгэлдээ буй өөрийн хүмүүсийг тэрээр аврахгүйг би хэлсний учир болой.

37 Мөн тэрээр “нүгэлдээ буй тэднийг аварч чадахгүй хэмээн би та нарт дахин хэлнэ; учир нь би түүний үгийг үгүйсгэж чадахгүй мөн тэрээр “цэвэр бус нэг ч зүйл “тэнгэрийн хаант улсыг өвлөж чадахгүй гэж хэлсэн; тиймийн тул, та нар тэнгэрийн хаант улсыг өвлөхгүйгээр та нар хэрхэн аврагдаж чадах билээ? Тиймийн тул, та нар нүгэлдээ байхдаа аврагдаж чадахгүй.

38 Эдүгээ Зиезром түүнд дахин хэлэв: Бурханы Хүү нь

24a 1 Тим. 6:10; Тит. 1:11.

31a Алма 10:7–10.

34a Хил. 5:10–11.

37a 1 Кор. 6:9–10.

б 1 Ниф. 15:33;

Алма 40:26;

3 Ниф. 27:19.

су Бурханлиг бус.

в су Бурханы хаант улс буюу

Тэнгэрийн хаант улс.

чухам тэрхүү Мөнхийн Эцэг юм уу?

39 Мөн Амюлек түүнд хэлэв: Тийм ээ, тэр бол тэнгэр мөн газрын, мөн тэдэнд багтах “бүх зүйлийн чухамхүү тэр ⁶Мөнхийн Эцэг буюу; тэр бол эхлэл ба төгсгөл, эхнийх бөгөөд эцсийнх болой;

40 Мөн тэрбээр өөрийн хүмүүсийг ⁶гэтэлгэхээр ⁶дэлхийд ирэх болно; мөн тэрээр өөрийнх нь нэрэнд итгэх тэдний зөрчлүүдийг өөр дээрээ ⁶авах болно; мөн эдгээр нь мөнх амьдралыг авах тэд болой, мөн өөр хэнд ч аврал ирэхгүй.

41 Тиймийн тул ёс бусыг үйлдэгчдийн үхлийн хүлээс алдуурахаас бусдаар, ⁶гэтэлгэл хийгдээгүй мэтээр үлдэнэ; учир нь болгоогтун, ⁶бүгд нас барагсдын дундаас босч мөн Бурханы өмнө зогсоно, мөн үйлүүдийнхээ дагуу ⁶шүүгдэх тэр өдөр ирэх болно.

42 Эдүгээ зуурдын үхэл гэж нэрлэгдсэн үхэл байдаг; мөн Христийн үхэл нь энэ зуурдын үхлийн “хүлээсийг тайлнаар, бүгд зуурдын үхлээс босгогдох болно.

43 Сүнс мөн бие төгс хэлбэрээрээ “дахин нэгдэх болно; бүр бид одоо энэ цагт байгаа

шигээ, үе болон мөч аль аль нь зохих байдалдаа сэргээгдэх болно; мөн бид Бурханы өмнө одоогийнхоо мэдэж буйн адил мэдлэгтэйгээр, мөн өөрсдийн бүх ⁶гэмийн тодорхой ⁶дурдатгалтайгаар зогсохоор аваачигдах болно.

44 Эдүгээ энэ сэргээлт нь бүгдэд, настай мөн залуу аль алинд нь, боол мөн чөлөөт аль алинд нь, эрэгтэй эмэгтэй аль алинд нь, ёс бусыг үйлдэгчид хийгээд зөв шударгыг үйлдэгчдэд аль алинд нь ирэх болно; мөн бүр тэдний толгойн үсний нэг ширхэг нь ч гээгдэхгүй болой; харин бүх зүйл төгс хэлбэрээрээ одоогийнхоо адил өөрөөр хэлбэл биедээ буй мэтээр, ⁶сэргээгдэх болно, мөн нэгэн ⁶Мөнхийн Бурхан болох Хүү Христ, мөн ⁶Эцэг Бурхан, мөн Ариун Сүнсний тавцангийн өмнө өөрсдийн сайн ч бай, мөн хилэнцэт ч бай, тэрхүү үйлүүдийнхээ дагуу ⁶шүүгдэхээр авчрагдаж мөн яллагдах болно.

45 Эдүгээ, болгоогтун, би танд зуурдын биеийн үхлийн талаар мөн түүнчлэн зуурдын биеийн “амилуулалтын талаар ярьсан билээ. Энэ зуурдын бие ⁶үхэшгүй биед,

39a Кол. 1:16; Мозая 4:2.
б Иса. 9:6.

40a Ром 11:26–27.

б су Дэлхий.

в Ег. 34:6–7; Иса. 53:5;

1 Иохан 2:2;

Мозая 14:5; 15:12;

С ба Г 19:16–19.

41a Алма 12:18;

С ба Г 88:33.

б Илч. 20:12–13;

Алма 42:23.

в су Эцсийн шүүлт.

42a Алма 12:16.

43a 2 Ниф. 9:13;

Алма 40:23.

б су Гэм.

в 2 Ниф. 9:14;

Мозая 3:25;

Алма 5:18.

44a Алма 41:12–15.

б 3 Ниф. 11:27, 36.

су Бурхан, Бурхан тэргүүтэн.

в су Бурхан, Бурхан тэргүүтэн — Эцэг Бурхан.

г Илч. 20:12–13.

45a Алма 40:23;

С ба Г 88:16.

б су Мөнх бус, Мөнх бус байдал.

тодруулбал үхлээс, бүр амьдралын эхний үхлээс ⁶босгогдоно, тэд дахин нэгээхэн ч үхэж чадахгүй болно хэмээн би та нарт хэлнэ; тэдний сүнснүүд биестэйгээ хэзээ ч салгагдахгүйгээр нэгдэнэ; тэд дахин ялзралыг үзэж чадахгүй болж, тийн бүхэл бүтнээрээ ⁹сүнсний хийгээд үхэшгүй байдалтай болно.

46 Эдүгээ, Амюлек эдгээр үгсийг дуусгахад хүмүүс дахин гайхан цочирдож эхлэв, мөн түүнчлэн Зиезром салгалж эхлэв. Мөн тийн Амюлекийн үгс төгсөж, өөрөөр хэлбэл миний бичиглэсэн бүхэн нь энэ болов.

БҮЛЭГ 12

Алма Зиезромтой маргалдав— Бурханы нууцууд зөвхөн итгэлтнүүдэд л өгөгдөж болно— Хүмүүн нь өөрсдийн бодол, бишрэл, үгс мөн үйлүүдээрээ шүүгддэг— Ёс бусыг үйлдэгчид сүнсний үхлийг амсах болно— Зуурдын энэ амьдрал бол сорилтын нөхцөл юм— Гэтэлгэлийн төлөвлөгөө нь Амилуулалтыг мөн итгэлээр дамжуулан нүглүүдийн ангижралыг улируулан тохиох болгодог— Наманчлагчид Төрсөн Ганц Хүүгээр дамжуулан нигүүлслийг авах эрхтэй. Ойролцоогоор мээ 82 он.

Эдүгээ Амюлекийн үгс Зиезромыг чимээгүй болгосныг

Алма хараад, Амюлек түүнийг “худал хэлж мөн өөрийг нь сүйрүүлэхээр мэхэлж байгааг илчилснийг нь тэр мэдсэний учир, мөн өөрийн зөрчлийг ⁶ухамсарласнаас түүний салгалж эхлэхийг Алма хараад, тэрээр амаа нээж мөн түүнд ярьж, мөн Амюлекийн үгсийг батлан, мөн юмсыг илүүгээр тайлбарлан, өөрөөр хэлбэл Амюлекийн хийснээс илүүгээр судруудыг дэлгэн тайлбарлаж эхлэв.

2 Эдүгээ Зиезромд ярьсан Алмагийн үгс эргэн тойронд нь байсан хүмүүст дуулдав; учир нь түмэн олон агуу олон тоотой байв, мөн тэрээр ийм маягаар ярив:

3 Эдүгээ Зиезром, таны худал хэлж мөн залилсан тань баригдсаныг харлаа, учир нь та зөвхөн хүмүүнд худал хэлсэн бус, харин та Бурханд худал хэллээ; учир нь болгоогтун, тэр таны бүх “бодлуудыг мэддэг, мөн таны бодлууд түүний Сүнсээр бидэнд мэдүүлэгдсэнийг та харж байна;

4 Мөн биднийг гадуурхан мөн биднийг зайлуулахаар, энэ хүмүүсийг бидний эсрэг болгож болохын тулд тэднийг та хуурч мөн худал хэлэхийн тулд таны төлөвлөгөө чөтгөрийн зальт аргын дагуу машинд зальт төлөвлөгөө байсныг бид мэдсэнийг та харж байна—

45в су Амилуулалт.

г Илч. 21:4;

С ба Г 63:49; 88:116.

д 1 Кор. 15:44.

12 1а Алма 11:20–38.

б су Ухамсар.

3а Иаков 2:5;

Алма 10:17;

С ба Г 6:16.

5 Эдүгээ энэ нь таны “дайсны төлөвлөгөө байсан, мөн тэрээр өөрийн хүчийг танаар дамжуулан үзүүлсэн бөлгөө. Эдүгээ би танд хэлснийг бүгдэд хэлж буйг та нар санаасай хэмээнэ.

6 Мөн болгоогтун, тэр та нарыг боолчлох хүчнийхээ дагуу үүрдийн устгалд доош гинжилж болохын тулд, тэр та нарыг “гинжээрээ ороож болохын тулд, тэр та нарыг эрхшээлдээ авчрахын тулд, энэ бол дайсны, тэрбээр энэ хүмүүсийг барихаар тавьсан урхи байсныг би та бүгдэд хэлнэ.

7 Эдүгээ Алма эдгээр үгсийг ярихад Зиезром үлэмж ихээр салгалж эхлэв, учир нь тэрээр Бурханы хүчинд улам улам бүр үнэмшүүлэгдэж байв; мөн түүнчлэн Алма Амюлек нарт өөрийнх нь тухай мэдлэг буй гэдэгт тэрээр үнэмшүүлэгдэв, учир нь түүний зүрхний бодлууд болоод санаануудыг тэд мэдсэнд тэрээр үнэмшүүлэгдэв; учир нь бошиглолын суу билгийн дагуу тэд эдгээр зүйлийг мэдэж болохын тулд тэдэнд хүч өгөгдсөн байв.

8 Мөн Зиезром Бурханы хаант улсын талаар илүүг мэдэж болохын тулд тэрээр тэднээс шаргуугаар лавлаж эхлэв. Мөн тэр Алмад хэлэв:

нас барагсдын амилуулалтын талаар Амюлекийн ярьсан тэр, шударга, шударга бус аль аль нь бүгд нас барагсдын дундаас босох болно, мөн өөрсдийн хийсэн үйлүүдийнхээ дагуу шүүгдэхээр Бурханы өмнө зогсохоор авчрагдана гэдэг нь юу гэсэн утгатай билээ?

9 Мөн эдүгээ Алма эдгээр зүйлийг түүнд тайлбарлаж эхлэв, өгүүлсэн нь: Бурханы “нууцуудыг мэдэх нь олонд өгөгдсөн юм; гэсэн хэдий ч тэдний түүнд хандуулах тэрхүү анхаарал мөн шаргуу байдлын хэрээр хүмүүний үрсэд соёрхдог үгсийн “зөвхөн тэр хэсгийн дагуу л бус аваас хуваалцаж үл болно гэсэн чанд хатуу зарлигийг тэд хүлээсэн байдаг.

10 Мөн тиймийн тул, зүрх сэтгэлээ “хатууруулах тэр нь, мөнхүү тэр нь үгийн “багахан хувийг хүлээж авдаг; мөн зүрх сэтгэлээ “хатууруулахгүй, түүнд тэдгээрийг бүрэн дүүрэн мэдэх хүртэл нь Бурханы нууцуудыг түүнд мэдүүлэх хүртэл үгийн илүү их хэсэг “өгөгддөг болой.

11 Мөн зүрх сэтгэлээ хатууруулах, тэдэнд нууцуудын талаар “юу ч мэдэхгүй болох хүртэл нь үгийн илүү бага “хэсэг өгөгддөг; мөн тэгээд тэд чөтгөрийн боолчлолд

5а су Чөтгөр.
6а Алма 5:7–10.
9а Алма 26:22.
су Бурханы
нууцууд.
б Иохан 16:12;

Алма 29:8;
3 Ниф. 26:8–11;
Ифер 4:7.
10а 2 Ниф. 28:27;
Ифер 4:8.
б С ба Г 93:39.

в су Даруу, Даруу
байдал.
з 2 Ниф. 28:30;
С ба Г 50:24.
11а су Урвалт.
б Мат. 25:29.

автагдаж, мөн түүний тааллаар доош устгал уруу удирдагддаг. Эдүгээ “тамын гинж гэдэг нь ийм учиртай ажгуу.

12 Мөн “үхэл хийгээд энэхүү зуурдын байдлаас үхэшгүй байдалд босгогдохоор, мөн өөрсдийн үйлүүдийн дагуу “шүүгдэхээр, Бурханы тавцангийн өмнө авчрагдах талаар Амюлек тодорхой ярьсан ажгуу.

13 Тэгээд хэрэв бидний зүрх сэтгэл хатуурсан бол, тийм ээ, хэрэв бид үгний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулсан бол, үүний хэрээр энэ нь бидний дотор олдоогүй аваас, тэгвэл бидний нөхцөл аймшигтай байх болно, учир нь бид буруутгагдах болно.

14 Учир нь бидний “үгс биднийг буруутгах болно, тийм ээ, бүх үйлс маань биднийг буруутгах болно; бид толбогүйгээр эс тогтоогдох болно; мөн түүнчлэн бодлууд маань ч биднийг буруутгах болно; мөн энэ аймшигт нөхцөлд бид өөрсдийн Бурхан өөд маань харж үл зүрхлэх болно; мөн түүний оршихуйгаас биднийг нуухын тулд, өөрсөд дээрээ “нуран унахыг хад “уулсад бид тушааж чаддаг сан бол сэтгэл маань ихэд баяртай байх сан биз ээ.

15 Гэвч ийм байх аргагүй юм;

бид урагшлан мөн түүний өмнө, түүний алдар суугийн дор, мөн түүний хүчний дор, мөн түүний чадал, сүр жавхлангийн хийгээд эзэгнэлийн дор зогсон, түүний бүхий л “шүүлтүүд шударга, тэрээр бүхий л үйлстээ шударга, мөн тэрээр хүмүүний үрсэд нигүүлсэнгүй, мөн тэрээр түүний нэрэнд итгэн мөн наманчлалд нийцэх үр жимсийг авчрах хүн бүрийг аврах бүх хүчийг эзэмддэг болохыг үүрдийн “ичгүүртээ хүлээн зөвшөөрөх ёстой.

16 Мөн эдүгээ болгоогтун, би та нарт хэлнэ, тэгээд үхэл, бүр сүнсний үхэл болох хоёр дахь “үхэл ирэх болно; тэгээд зуурдын “үхлээр нүгэлдээ нөгчсөн хэн боловч, сүнсний үхлээр “үхэх цаг болно; тийм ээ, зөв шударгад хамаарах зүйлүүдийн хувьд тэрээр үхэх болно.

17 Тэгээд тэдний тарчлалууд дөл нь үүрд мөн үргэлж дүрэлзэх галт мөн хүхэрт чулуун “нуур лугаа адил байх цаг болно; мөн тэгээд өөрийн тааллын дагуу эзэгнэн захирах Сатаны хүч хийгээд боолчлолын дор тэд үүрдийн устгалд гинжлэгдэх болно.

18 Тиймээс, би та нарт хэлнэ, тэд “гэтэлгэл огт хийгдээгүй мэт байх болно; учир нь тэд

11в Сур. үгс 9:18;

2 Ниф. 2:29.

су Там.

г Иохан 8:34;

2 Ниф. 28:19.

12а Алма 11:41–45.

б су Эцсийн шүүлт.

14а Мат. 12:36;

Иаков 3:6;

Мозая 4:29–30.

б Иов 34:22;

2 Ниф. 12:10.

в Хосеа 10:8;

2 Ниф. 26:5.

15а 2 Петр 2:9.

су Шударга ёс.

б Мозая 3:25.

16а су Сүнсний үхэл.

б Алма 11:40–45.

в 1 Ниф. 15:33;

Алма 40:26.

17а Илч. 19:20; 21:8;

Мозая 3:27.

18а Алма 11:41.

Бурханы шударга ёсны дагуу гэтэлгэгдэж чадахгүй; мөн алзрал гэж үгүйн учир тэд ⁶үхэж ч чадахгүй болно.

19 Эдүгээ улиран тохиох дор Алма эдгээр үгсийг ярихаа төгсгөл болгоход, хүмүүс илүү ихээр гайхан цочирдож эхлэв;

20 Гэвч тэдний дундах ерөнхий захирагч болох Антиана гэгч нэгэн, урагшилж мөн түүнд хэлэв: Хүмүүс нас барагсдын дундаас босон мөн энэ зуурдын байдлаас “үхэшгүй байдалд өөрчлөгдөнө, тиймээс, сүнс хэзээ ч үхэж чадахгүй хэмээн таны хэлсэн тэр чинь юу вэ?

21 Анхны эцэг эхийг маань “Еденийн цэцэрлэгт орон, амьдралын модны жимснээс хүртэн үүрд амьдрах вий хэмээн, Бурхан дорно хэсэгт нь ⁶херубим болон галт илд байрлуулсан хэмээн өгүүлэх судар ямар утгыг агуулна вэ? Мөн ийн тэд үүрд амьдрах боломж огт байгаагүйг бид харж байна.

22 Эдүгээ Алма түүнд хэлсэн нь: Энэ бол миний тайлбарлах гэж байсан зүйл. Эдүгээ Адам хориглогдсон “жимснээс хүртсэнээр Бурханы үгийн дагуу ⁶унасныг бид харж байна; мөн тийн, түүний

уналтаар, бүх хүн төрөлхтөн ⁶төөрөлдсөн мөн унасан хүмүүс болсныг бид харж байна.

23 Мөн эдүгээ болгоогтун, би та нарт хэлнэ, тэр цагт хэрэв Адам амьдралын модны жимснээс “хүртэх боломжтой байсан бол, үхэл гэж үгүй байх сан, мөн Бурханыг худалч болгох үг хүчингүй болох сон, учир нь тэрээр: ⁶Хэрэв чи идэх аваас, чи гарцаагүй үхэх болно хэмээн хэлсэн билээ.

24 Мөн “үхэл, тийм ээ, Аミュлекээр яригдсан зуурдын үхэл гэгдэх тэрхүү үхэл хүмүүн төрөлхтний дээр ирдгийг бид харж байна; гэсэн хэдий ч ⁶хүмүүн наманчилж болно хэмээн түүнд хугацаа өгөгдсөн юм; тиймийн тул энэ амьдрал нь сорилтын нөхцөл; Бурхантай уулзахаар “бэлтгэх цаг; нас барагсдын амилуулалтын дараа ирэх, биднээр хэлэгдсэн тэрхүү төгсгөлгүй байдалд бэлтгэх цаг болсон ажгуу.

25 Эдүгээ, хэрэв дэлхийн үүслээс зэхэгдсэн “гэтэлгэлийн төлөвлөгөө байгаагүй сэн бол, нас барагсдын ⁶амилуулалт гэж үгүй байх сан; гэвч яригдсан үхэгсдийн амилуулалтыг улиран тохиохоор

18б Илч. 21:4;
Алма 11:45;
С ба Г 63:49.

20а су Мөнх бус, Мөнх бус байдал.

21а су Еден.

б Эхл. 3:24; Алма 42:2;
Моце 4:31.
су Херубим.

22а Эхл. 3:6;
2 Ниф. 2:15–19;
Мозая 3:26.

б су Адам Ева хоёрын Уналт.
в Мозая 16:4–5.

23а Алма 42:2–9.
б Эхл. 2:17.

24а су Биеийн үхэл.

б 2 Ниф. 2:21;
Моце 5:8–12.
в Алма 34:32–35.

25а су Гэтэлгэлийн төлөвлөгөө.

б 2 Ниф. 2:8;
Алма 7:12; 42:23.

болгох, гэтэлгэлийн төлөвлөгөө бэлтгэгдсэн билээ.

26 Мөн эдүгээ болгоогтун, бидний анхны эцэг эх явж мөн “амьдралын модны жимснээс хүртэх боломжтой байсан бол, бэлтгэх нөхцөл гэж үгүй, тэд үүрд зовлонд байх байсан; мөн тийн ⁶гэтэлгэлийн төлөвлөгөө саатуулагдаж, мөн ямар ч үр дүнгүйн улмаас Бурханы үг хүчингүй байх байсан.

27 Гэвч болгоогтун, энэ нь тийм байсангүй; гэвч хүмүүнд, тэд үхэх ёстой нь “тогтоогдов; мөн үхлийн дараа, тэд ⁶шүүлтэд, бүр бидний ярьсан төгсгөл болох тэрхүү шүүлтэнд ирэх ёстой.

28 Мөн Бурхан эдгээр зүйлийг хүмүүнд ирэхийг нь тогтоосны дараа, болгоогтун, тэгээд тэрээр тэдэнд өөрийн тогтоосон эдгээр зүйлүүдийн талаар хүмүүн мэдэх нь зайлшгүй байсныг харав;

29 Тиймийн тул тэдэнтэй ярилцуулахаар түүний сүр жавхланг хүмүүнд харуулах “тэнгэр элчүүдийг тэрээр илгээсэн ажгуу.

30 Мөн тэд тэр цагаас хойшид түүний нэрийг дуудаж эхэлсэн билээ; тиймийн тул Бурхан хүмүүнтэй “ярилцаж, мөн тэдэнд дэлхийн ⁶үүслээс

бэлтгэгдсэн байсан ⁶гэтэлгэлийн төлөвлөгөөг мэдүүлсэн юм; мөн тэр үүнийг тэдний итгэл хийгээд наманчлал мөн тэдний ариун үйлүүдийнх нь дагуу тэдэнд мэдүүлсэн болой.

31 Иймийн тул, тэрээр хүмүүнд “зарлигуудыг өгсөн бөлгөө, зуурдын болох зүйлүүдийн талаарх ⁶эхний зарлигуудыг тэд анх зөрчсөн учраас, мөн бурхдын адил хилэнцээс сайныг ⁶ялгаж мэдэх болж, тэд өөрсдийгөө ‘үйлдэх байдалд тавьж, өөрөөр хэлбэл өөрсдийн таалал хийгээд хүслийн дагуу хилэнцийг эсвээс сайныг үйлдэх байдалд тавигдсан буюу —

32 Тиймийн тул Бурхан тэдэнд гэтэлгэлийн төлөвлөгөөг “мэдүүлсний дараа тэдэнд зарлигуудыг өгсөн билээ, тэд хилэнцийг хийх ёсгүй, түүний шийтгэл нь хоёрдахь ⁶үхэл юм, зөв шударгад хамаарах зүйлүүдийн хувьд үүрдийнх болох тэрхүү үхэл; учир нь ийм нэгэнд гэтэлгэлийн төлөвлөгөө хүчгүй, өөрөөр хэлбэл Бурханы туйлын сайн сайхны дагуу ⁶шударга ёсны үйлүүд устгагдах боломжгүй юм.

33 Гэвч Бурхан өөрийн Хүү-

26a Эхл. 2:9;
1 Ниф. 15:36;
Алма 32:40.
б Алма 34:8–16;
42:6–28;
Мосе 6:59–62.
27a Иов 7:1;
Евр. 9:27;
С ба Г 42:48.
б су Эцсийн шүүлт.

29a Моро. 7:25, 31;
С ба Г 29:42.
30a Мосе 5:4–5; 6:51.
б су Гэтэлгэлийн
төлөвлөгөө.
в Мозая 18:13;
Алма 13:3, 5, 7–8.
31a су Бурханы
зарлигууд.
б Эхл. 2:16–17;

2 Ниф. 2:18–19.
в Эхл. 3:22–23;
Мосе 4:11.
г 2 Ниф. 2:16.
су Сонгох эрх.
32a Мосе 5:4–9.
б су Сүнсний үхэл.
в Мозая 15:27;
Алма 34:15–16; 42:15.

гийн нэрэнд хүмүүнийг дуудсан юм, (бэлтгэгдсэн тэр гэтэлгэлийн төлөвлөгөө нь ийм) хэлрүүн: Хэрэв та нар наманчилж мөн зүрх сэтгэлээ эс хатууруулах аваас би та нарт өөрийн Төрсөн Ганц Хүүгээр дамжуулан нигүүлсэнгүй хандах болно;

34 Тиймийн тул, наманчлах мөн зүрх сэтгэлээ эс хатууруулах хэн боловч, тэрээр нүглүүдийнхээ “ангижралын төлөө, миний Төрсөн Ганц Хүүгээр дамжуулан ⁶нигүүлсийг хүртэх эрхтэй болно; мөн эдгээр нь миний ⁶амралтад орох болно.

35 Мөн зүрх сэтгэлээ хатууруулах мөн алдсыг үйлдэх хэн боловч, болгоогтун, тэрээр миний амралтад орохгүйг бибээр уур хилэндээ андгайлна.

36 Мөн эдүгээ, ах дүүс минь, болгоогтун хэрэв та нар зүрх сэтгэлээ хатууруулах аваас та нар Их Эзэний амралтад орохгүйг би та нарт хэлнэ; тиймийн тул та нарын алдас, тэрээр анхны “өдөөн хатгалт лугаа адил уур хилэнгээ та нарын дээр илгээх болгон түүнийг өдөөн хатгана, тийм ээ, түүний үгийн дагуу эцсийн өдөөн хатгалт эхнийх адилаар, бодгалиудын тань үүрдийн ⁶устгалд; тиймийн тул, түүний үгийн дагуу, эцсийн үхэлд эхний адилаар хүргэх буюу.

37 Мөн эдүгээ, ах дүүс минь, нэгэнт бид эдгээр зүйлийг мэддэг, мөн эдгээр нь үнэн учир, бид Их Эзэн Бурханаа “уцаарлуулж, түүний бидэнд өгсөн эдгээр хоёр дахь зарлигуудын хувьд хилэгнэлээ бидний дээр доош илгээхгүйн тулд наманчилцгаая мөн зүрх сэтгэлээ үл хатууруулцгаая; харин түүний үгийн дагуу бэлтгэгдсэн ⁶Бурханы амралтад орцгооё.

БҮЛЭГ 13

Эрчүүд өөрсдийн үлэмж итгэл мөн сайн үйлүүдийнхээ учир дээд санваартан болж дуудагддаг — Тэд зарлигуудыг заах ёстой — Тэд зөв шударга байдлаар дамжин ариусгагдаж мөн Их Эзэний амралтад орох бөлгөө — Мелкизедек нь тэдний нэг байв — Тэнгэр элчүүд уг нутаг даяар баярт мэдээг зарлаж байв — Тэд Христийн бодит ирэлтийг илчлэх болно. Ойролцоогоор мээ 82 он.

Мөн түүнчлэн, ах дүүс минь, Их Эзэн Бурхан өөрийн хүүхдүүдэд эдгээр зарлигийг өгсөн тэр цаг тийш би та нарын оюун санааг хандуулмаар байна; мөн Их Эзэн Бурхан өөрийн Хүүгийн жаягийн дагуу ариун жаягийнхаа дагуу хүмүүст эдгээр зүйлийг заах санваартнуудыг “томилсныг та нар санаасай хэмээнэ би.

2 Мөн тэдгээр санваартнууд,

34a су Нигүүлсэнгүй, Нигүүлсэл.
б су Нүглүүдийн ангижрал.

в су Амрах.
36a Иаков 1:7–8;
Алма 42:6, 9, 14.
б су Ял.

37a 1 Ниф. 17:30;
Иаков 1:8; Хил. 7:18.
б Алма 13:6–9.
13 1a Абр. 2:9, 11.

хүмүүс түүний Хүүгийн гэтэлгэлийг ямар маягаар хүсэн хүлээхийг мэдэж болох тийм ^амаягаар түүний Хүүгийн ^бжаягийн дагуу томилогдсон билээ.

3 Мөн тэдний томилогдсон тэр маяг нь энэ буюу — Бурханы “зөгнөх мэдлэгийн дагуу тэдний үлэмжийн итгэл хийгээд сайн үйлүүдээс үндэслэн дэлхийн ^бүүслээс ^адуудагдсан мөн ^вбэлтгэгдсэн билээ; эхнээсээ сайныг эсвээс хилэнцийг ^асонгохоор үлдээгдсэн ажгуу; тиймийн тул тэд сайныг сонгосны учир, мөн үлэмж агуу ^витгэлийг бодитой болгосон учир, тэд ариун дуудлагад, тийм ээ, ийм хүмүүсийн тул гэтэлгэл бэлтгэгдсэний дагуу мөн түүнтэй нэгэн цагт бэлтгэгдсэн тэрхүү ариун дуудлагуудаар ^вдуудагдсан ажээ.

4 Мөн тийн тэд итгэлийнхээ учир энэ ариун дуудлагад ^адуудагдсан билээ, гэтэл бусад зарим нь зүрх сэтгэл нь хатуугийн мөн оюун нь харалганы учир Бурханы Сүнсийг эсэргүүцдэг, харин хэрэв ийм байгаагүй аваас өөрсдийнх нь ах дүүсийн адил тэдэнд агуу ^бболомж байж болох байсан.

5 Өөрөөр хэлбэл эцэст нь, эхнээсээ тэд ах дүүстэйгээ хамт ^аадил байдалд байв; тийн энэ ариун дуудлага дэлхийн үүслээс зүрх сэтгэлээ үл хатууруулах иймүүдэд зориулан бэлтгэгдсэн нь, бэлтгэгдсэн тэр болох Төрсөн Ганц Хүүгийн цагаатгал үүнд мөн үүгээр байх бөлгөө —

6 Мөн тийн тэд ч бас түүний ^аамралтад орж болохын тулд хүмүүний үрсэд түүний зарлигуудыг заахаар энэхүү ариун дуудлагаар дуудагдаж, мөн Бурханы ариун жаягийн дээд санваарт томилогдсон буюу —

7 Энэхүү дээд санваар нь дэлхийн үүслээс байсан жаяг болох түүний Хүүгийн жаягийн дагуу билээ; эсвээс өөр үгсээр бол, ^аөдрүүдийн эхлэл буюу жилүүдийн төгсгөлгүйгээр бүх зүйлийг ^бзөгнөх мэдлэгийнх нь дагуу, үүрд мөнхөөс бүх үүрд мөнхөд бэлтгэгдсэн билээ —

8 Эдүгээ тэд энэ маягаар ^атомилогдсон ажгуу — ариун дуудлагаар дуудагдаж, мөн ариун ёслолоор томилогдож, мөн ариун жаягийн дээд санваарыг тэд өөрсдийнхөө дээр авах, энэхүү дуудлага хийгээд ёслол, мөн дээд

2а Алма 13:16.

б С ба Г 107:2–4.

3а С ба Г 38:2.

б Алма 12:25, 30.

сү Мөнх бус
байдлын өмнөх
амьдрал.

в С ба Г 127:2.

сү Сонгогдсон;
Урьдчилсан

томилолт.

г С ба Г 138:55–56.

д сү Сонгох эрх.

е сү Итгэл.

ё сү Дуудах,
Бурханаас
дуудагдах,
Дуудлага;
Санваартан.

4а Ифер 12:10.

б 1 Ниф. 17:32–35.

5а 2 Ниф. 26:28.

6а Алма 12:37; 16:17.
сү Амрах.

7а Евр. 7:3.

б сү Бурхан, Бурхан
тэргүүтэн.

8а С ба Г 84:33–42.

сү Мелкизедек
санваар.

санваар нь эхлэл бас төгсгөлгүй болой—

9 “Ач ивээл, тэгш байдал, мөн үнэн байдлаар дүүрэн, өдрүүдийн эхлэл буюу жилүүдийн төгсгөлгүй, Эцэгийн Төрсөн Ганц болох, Хүүгийн жаягийн дагуу тэд тийн үүрд ^бдээд санваартнууд болдог. Мөн тийн байх болой. Амен.

10 Эдүгээ, ариун жаяг, өөрөөр хэлбэл энэхүү “дээд санваарын талаар миний хэлснээр, томилогдож мөн Бурханы дээд санваартан болсон нь олон байв; мөн энэ нь тэдний үлэмж итгэл хийгээд ^бнаманчлал, мөн Бурханы өмнөх тэдний зөв шударга байдлаас нь үндэслэсэн байв, мөхөхийн оронд наманчлан мөн зөв шударгыг үйлдэхийг тэд сонгосны учир буюу;

11 Тиймийн тул тэд энэ ариун жаягийн дагуу дуудагдаж мөн “ариусгагдан, мөн тэдний ^бөмсгөлүүд Хурганы цусаар угаагдан цагаан болсон юм.

12 Эдүгээ тэд, “Ариун Сүнсээр ^бариусгагдсаны дараа, тэдний өмсгөлүүд цагаан болгогдсон учир, тэд Бурханы өмнө “цэвэр мөн толбогүй байсан учир, ‘жигшлээс

өөрөөр ^бнүглийг үзэж эс чадна; мөн цэвэршигдэж мөн Их Эзэн Бурханыхаа амралтад орсон нь олон, үлэмж олон байв.

13 Мөн эдүгээ, ах дүүс минь, та нар өөрсдийгөө Бурханы өмнө даруусгаж, мөн та нар түүнчлэн уг амралтад орж болохын тулд наманчлалд нийцэх “үр жимсийг та нар гаргаасай хэмээнэ би.

14 Тийм ээ, бүр миний ярьсан жаягийн дагуу дээд санваартан асан, түүнчлэн өөр дээрээ дээд санваарыг үүрд авсан “Мелкизедекийн өдрүүд дэх хүмүүсийн адил өөрсдийгөө даруусга.

15 Мөн энэ нь “Абрахам түүнд ^баравны нэгийг төлдөг асан Мелкизедек байв; тийм ээ, бүр бидний эцэг Абрахам өөрийн бүх эзэмшсэний аравны нэгийг төлдөг байсан билээ.

16 Эдүгээ эдгээр “ёслолууд, үүгээр хүмүүс Бурханы Хүүг хүсэн хүлээж болохын тулд энэ маягаар өгөгдсөн аж, мөн энэ нь түүний жаягийн ^бдүрслэл, өөрөөр хэлбэл энэ нь түүний жаяг, мөн энэ нь тэд нүглүүдийнхээ ангижралын тулд түүнийг харуулдан

9а 2 Ниф. 2:6.
су Ач ивээл.
б су Дээд санваартан.

10а С ба Г 84:18–22.
б су Наманчлах, Наманчлал.

11а Мосе 6:59–60.
б 1 Ниф. 12:10;
Алма 5:21–27;
3 Ниф. 27:19–20.

12а Ром 8:1–9.
су Ариусгал.
б су Ариун Сүнс.
в су Цэвэр ариун, Цэвэр ариун байдал.

г Сур. үгс 8:13;
Алма 37:29.
д Мозая 5:2;
Алма 19:33.

13а Лук 3:8.

14а С ба Г 84:14. исо,
Эхл. 14:25–40.
су Мелкизедек.

15а су Абрахам.
б Эхл. 14:18–20;
Малах. 3:8–10.
су Аравны нэг төлөх, Аравны нэг.

16а су Ёслолууд.
б су Бэлэгдлийн.

хүлээж болохын тулд, тэд Их Эзэний амралтад орж болохын тулд хийгдсэн билээ.

17 Эдүгээ энэхүү Мелкизедек нь Салем нутгийн хаан байв; мөн түүний хүмүүс алдас мөн жигшүүрт хэргүүдийн хувьд хүчирхэгжсэн байв; тийм ээ, тэд бүгд төөрч одсон байв; тэд бүх төрлийн ёсон бусаар дүүрэн байв;

18 Гэвч Мелкизедек хүчит итгэлийг бодитой болгож, мөн “Бурханы ариун жаягийн дагуу дээд санваарын албан тушаалыг хүлээн авсны учир, өөрийн хүмүүст наманчлалыг номлосон ажгуу. Мөн болгоогтун, тэд наманчилжээ; мөн Мелкизедек өөрийн өдрүүдэд уг нутагт амар амгаланг тогтоов; тиймийн тул тэрээр энх амгалангийн ханхүү гэж нэрлэгдсэн бөлгөө, учир нь тэр Салемын хаан байв; мөн тэрээр эцгийнхээ захиргаан дор засаглаж байв.

19 Эдүгээ, түүнээс өмнө “олон нь байж, мөн түүнчлэн дараа нь ч олон байв, гэвч илүү агуу нь ^бүгүй байлаа; тиймийн тул, тэд түүний тухай илүү чухалчлан дурдсан бөлгөө.

20 Эдүгээ би энэ хэргийг нарийвчлан ярих хэрэггүй; миний хэлсэн нь хангалттай. Болгоогтун, “судрууд та нарын өмнө байна; хэрэв та нар

тэдгээрийг ^бмушгин гуйвуулах аваас энэ нь та нарыг устгалд тань хүргэх болно.

21 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма эдгээр үгсийг тэдэнд хэлээд, тэрээр тэдний зүг гараа сунган мөн хүчирхэг хоолойгоор хашгирч, хэлрүүн: “Наманчлах цаг нь одоо болой, учир нь авралын өдөр ойртож байна;

22 Тийм ээ, мөн Их Эзэний дуу хоолой, тэнгэр элчүүдийн “амаар, үүнийг бүх үндэстнүүдэд тунхагладаг; тийм ээ, тэд агуу их баяслын баярт мэдээг мэдэж болохын тулд үүнийг тунхагладаг; тийм ээ, мөн тэрээр эдгээр баярт мэдээг өөрийн бүх хүмүүсийн дунд, тийм ээ, бүр газрын гадаргуугаар тарсан тэдэнд сонсгодог; иймийн тул тэдгээр нь бидэнд ирсэн бөлгөө.

23 Мөн тэдгээр нь бид ойлгож болохын тулд, бид алдаж чадахгүйгээр “тодорхой үгээр бидэнд мэдүүлэгдсэн билээ; мөн энэ нь бид харь нутагт ^бхэсэн бэдрэгчид болохын учир юм; тиймийн тул, бид тийн өндрөөр үнэлэгдсэн, учир нь өөрсдийн маань талбайн бүх хэсгүүдэд эдгээр баярт мэдээ бидэнд тунхаглагдан өгөгдсөн юм.

24 Учир нь болгоогтун, “тэнгэр элчүүд манай нутагт энэ цагт үүнийг олонд тун-

18a су Мелкизедек санваар.

19a Хил. 8:18;
С ба Г 84:6–16;
107:40–55.
б С ба Г 107:1–4.

20a су Судрууд.

б 2 Петр 3:16;
Алма 41:1.
21a су Наманчлах,
Наманчлал.
22a Алма 10:20.

23a 2 Ниф. 25:7–8; 31:3;
32:7; Иаков 4:13;
Ифер 12:39.
б Иаков 7:26.
24a Алма 10:10; 39:19.

хаглаж байна; мөн энэ нь тэрээр өөрийн алдар суугаар ирэх тэр цагт түүний үгийг хүлээн авахад хүмүүний үрсийн зүрх сэтгэлийг бэлтгэх зорилготой ажгуу.

25 Мөн эдүгээ түүний ирэх тухай тэнгэр элчүүдийн амаар бидэнд зарлагдах баярт мэдээг зөвхөн сонсохыг бид хүлээсэн бөлгөө; учир нь тэр цаг ирнэ, хэр ойрхон болохыг нь бид “мэдэхгүй. Энэ нь миний өдрүүдэд байх болоосой хэмээн Бурханд хандана; гэсэн ч энэ нь даруйхан эсвэл хожим ч бай, би үүнд баясах болно.

26 Мөн энэ нь түүний ирэлтийн цагт тэнгэр элчүүдийн амаар “шударга бөгөөд ариун хүмүүст мэдүүлэгдэх болно, тэдэнд байсан бошиглолын суу билгийн дагуу, түүний талаар тэдний ярьсны дагуу, бидний эцэг өвгөдийн үгс гүйцэлдэж болохын тулд болой.

27 Мөн эдүгээ, ах дүүс минь, зүрхнийхээ угаас, тийм ээ, бүр өвдөлтийг мэдрэх агуу зовнилоор, та нар миний үгсийг сонсоосой, мөн нүглүүдээсээ салаасай, мөн наманчлалынхаа өдрийг бүү хойшлуулаасай хэмээн “хүснэ би;

28 Харин та нар Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусган, түүний ариун нэрийг дуудаж, мөн та нар өөрсдийн

үүрч чадахаас илүүгээр “уруу таталтанд автагдахгүйн тулд үргэлж ^бсэрэмжилж мөн залбираасай, тэгснээр Ариун Сүнсээр удирдуулан, даруухан, “дөлгөөн, хүлцэнгүй, тэвчээртэй, хайр хийгээд бүхий л тэсвэрээр дүүрэн болоосой;

29 Их Эзэнд итгэх “итгэлтэй байгаасай; та нар мөнх амьдралыг хүлээн авах болно гэсэн найдварыг агуулаасай; та нар эцсийн өдөр өргөгдөн мөн түүний ^бамралтад орж болохын тул зүрх сэтгэлдээ “Бурханы хайрыг үргэлж тээгээсэй хэмээнэ.

30 Мөн та нар түүний хилэнг өөрсдийн дээр доош авчрахгүй байж болохын тулд, та нар “тамын гинжээр хүлэгдэхгүй байж болохын тулд, та нар хоёр дахь ^бүхлийг амсахгүй байж болохын тулд Их Эзэн та нарт наманчлалыг соёрхох болтугай.

31 Мөн Алма энэ номонд бичигдээгүй өөр олон үгсийг хүмүүст ярьсан билээ.

БҮЛЭГ 14

Алма, Амюлек хоёр шоронд хоригдож мөн занчигдав—Итгэгчид болон тэдний ариун судрууд галд шатаагдав—Эдгээр алагдагсад алдар суутайгаар Их Эзэнээр хүлээн авагджээ—Шоронгийн

25a 1 Ниф. 10:4;

3 Ниф. 1:13.

26a Амос 3:7;

Лук 2:8–11.

27a Мозая 28:3.

28a 1 Кор. 10:13.

б су Залбирал; Харах,

Харуул.

в су Номхон

дөлгөөн, Номхон

дөлгөөн байдал;

Тэвчээр.

29a Алма 7:24.

б С ба Г 84:24.

в С ба Г 20:31; 76:116.

су Энэрэл.

30a су Ял; Там.

б су Сүнсний үхэл.

хана цуурч мөн нурав—Алма, Амюлек хоёр чөлөөлөгдөж, мөн тэднийг хавчигчид алагдав. Ойролцоогоор мээ 82–81 он.

Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүмүүст ярихаа төгсгөл болгосны дараа тэдний олон нь түүний үгсэд итгэсэн болой, мөн наманчилж, мөн “судруудыг судалж эхлэв.

2 Гэвч тэдний ихэнх хэсэг нь Алма Амюлек хоёрыг тэд устгаж болно хэмээх хүсэлтэй байв; учир нь Зиезромд хандсан түүний үгс “тодорхойн учир тэд Алмад уурлаж байв; мөн түүнчлэн Амюлек тэдэнд ^бхудал хэлж, мөн тэдний хуулийг мөн түүнчлэн тэдний хуульчид болоод шүүгчдийг эсэргүүцэн доромжилсон хэмээн тэд хэлж байв.

3 Мөн түүнчлэн Алма Амюлек хоёрт тэд уурлаж байв; мөн тэд өөрсдийнх нь ёс бусын эсрэг тийм тодорхойгоор гэрчилсэн учир, тэднийг нууцаар үгүй хийхийг тэд эрэлхийлж байв.

4 Гэвч улиран тохиох дор тэд тэгсэнгүй; гэвч тэд тэднийг баривчлан мөн тэднийг бөх олсоор хүлж, мөн нутгийн ерөнхий шүүгчийн өмнө тэднийг аваачив.

5 Мөн хүмүүс урагшилж мөн тэдний эсрэг гэрчлэв—тэд хуулийг, мөн нутгийн хуульчид хийгээд шүүгчдийг, мөн түүнчлэн уг нутагт

байсан бүх хүмүүсийг доромжилсныг мэдүүлэв; мөн түүнчлэн ганцхан Бурхан буй, мөн тэрээр өөрийн Хүүг хүмүүсийн дунд илгээх боловч, тэр нь тэднийг үл аврах болно хэмээн гэрчилснийг; мөн олон иймэрхүү зүйлийг Алма Амюлек хоёрын эсрэг хүмүүс гэрчлэв. Эдүгээ энэ нь уг нутгийн ерөнхий шүүгчийн өмнө болов.

6 Мөнхүү улиран тохиох дор Зиезром яригдсан тэр үгсэд гайхсан ажгуу; мөн тэрээр түүнчлэн худал үгсээрээ хүмүүсийн дунд өөрийн бий болгосон оюун санааных нь харалган байдлын талаар мэджээ; мөн тэрээр өөрийн гэмийг “ухамсарласнаар түүний бодгаль ^бтарчилж эхлэв; тийм ээ, тэрээр тамын шаналлаар хүрээлэгдэж эхлэв.

7 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүмүүст хашгирч эхлэн, хэлсэн нь: Болгоогтун, би бол “гэмтэй, мөн эдгээр хүмүүс Бурханы өмнө толбогүй. Мөн тэрээр тэр цагаас хойш тэдний өмнөөс гуйж эхлэв; гэвч тэд түүнийг доромжилж хэлсэн нь: Та түүнчлэн чөтгөрт эзлэгдчихэв үү? Мөн тэд түүн дээр нулимж, мөн түүнийг, мөн түүнчлэн Алма, Амюлек нараар яригдсан үгсэд итгэсэн тэд бүгдийг өөрсдийнхөө дундаас ^бзайлуулав; мөн тэд тэднийг зайлуулж, мөн тэдний зүг чулуу шидүүлэхээр хүмүүсийг илгээв.

14 1a Хаад. дэд 22:8–13.
сү Судрууд.
2a Алма 12:3–7.

б Алма 10:27.
6a сү Ухамсар.
б Алма 15:5.

7a Алма 11:21–37.
б Алма 15:1.

8 Мөн тэд эхнэр болон хүүхдүүдийг нь хамтад нь авчирч, мөн Бурханы үгэнд итгэсэн эсвэл итгэхээр заалгасан хэнийг боловч тэднийг галд хаягдахаар болгов; мөн түүнчлэн тэд ариун судруудыг тээсэн цэдгүүдийг авчирч, тэдгээр нь галд шатаагдаж мөн устгагдаж болохын тулд тэдгээрийг түүнчлэн галд хаяв.

9 Мөнхүү улиран тохиох дор тэд Алма, Амюлек хоёрыг барьж, мөн тэд галд үрэгдсэн тэдний устгалыг үзэж болохын тулд тэднийг цаазын газарт аваачив.

10 Мөн галд үрэгдэж буй эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийн зовлонг Амюлек хараад, тэрээр түүнчлэн шаналав; мөн тэр Алмад хэлэв: Бид энэ аймшигт явдлыг харж яахан чадах билээ? Тиймийн тул гараа сунгацгаая, мөн бидэнд буй “Бурханы хүчийг үзүүлж, мөн тэднийг дөлнөөс аварцгаая.

11 Гэвч Алма түүнд хэлэв: Сүнс намайг гараа сунгах ёсгүй хэмээн албадаж байна; учир нь болгоогтун Их Эзэн тэднийг өөртөө “алдар суугаар хүлээн авах болно; өөрийн хилэгнэлд тэдний дээр үзүүлэх шүүлтүүд шударга байж болохын тулд, хүмүүс зүрх сэтгэлийнхээ хатуу байдлын дагуу тэдэнд энэ зүйлийг хийж болохыг, өөрөөр хэлбэл тэд энэ зүйлийг хийж

болохыг тэрээр зөвшөөрөх болно; мөн “гэм зэмгүй хүмүүсийн цус тэдний эсрэг гэрч болон зогсох болно, тийм ээ, мөн эцсийн өдөр тэдний эсрэг хүчтэйгээр хашгирах болно.

12 Эдүгээ Амюлек Алмад хэлэв: Болгоогтун, магадгүй тэд түүнчлэн биднийг ч шатаах болно.

13 Мөн Алма хэлэв: Энэ нь Их Эзэний тааллын дагуу байг. Гэвч, болгоогтун, бидний ажил дуусаагүй байна; тиймийн тул тэд биднийг шатаахгүй.

14 Эдүгээ улиран тохиох дор галд хаягдсан тэдний биес үрэгдэв, мөн түүнчлэн тэдэнтэй хаягдсан цэдгүүд ч бас үрэгдсэний дараа, нутгийн ерөнхий шүүгч ирж, мөн тэднийг хүлээстэй байхад нь Алма, Амюлек хоёрын өмнө зогсов; мөн тэр тэднийг гараараа хацар дээр нь цохиж, мөн тэдэнд хэлэв: Та нар үзсэн үүнийхээ дараа, галан мөн хүхэрт чулуун “нууранд хаягдах болно хэмээн энэ хүмүүст дахин номлох уу?

15 Болгоогтун, та нар галд хаягдсан тэднийг аврах хүчгүй байснаа харж байна; бас та нарын бишрэлд нэгдлээ гээд Бурхан ч тэднийг аварсангүй. Мөнхүү шүүгч тэднийг дахин хацар дээр нь цохиж, мөн асуув: Та нар өөрсдийнхөө төлөө юу хэлэх вэ?

10a Алма 8:30–31.
11a су Алдар суу.
b Дуул. 37:8–13;
Алма 60:13;

С ба Г 103:3.
су Шударга ёс.
в Мозая 17:10.
г су Санаатайгаар

алах, Санаатай
аллага.
14a Алма 12:17.

16 Эдүгээ энэ шүүгч, Гидеоныг алсан “Нихорын жаяг мөн бишрэлийн дагуу байв.

17 Мөнхүү улиран тохиох дор Алма Амюлек хоёр түүнд юу ч хариулсангүй; мөн тэр тэднийг дахин цохиж, мөн тэднийг шоронд хийлгэхээр албатуудад шилжүүлэв.

18 Мөн тэд шоронд гурав хоног хоригдсоны дараа, Нихорын адил бодолтой байсан олон “хуульчид хийгээд шүүгчид мөн санваартнууд мөн багш нар ирэв; мөн тэд шоронд тэднийг харахаар ирж мөн олон үгсийн талаар тэднийг шалгаав; гэвч тэд тэдэнд юу ч хариулсангүй.

19 Мөнхүү улиран тохиох дор уг шүүгч тэдний өмнө зогсоод, мөн хэлэв: Та нар яагаад энэ хүмүүсийн үгсэд хариулахгүй байна? Та нарыг дөлөнд илгээх хүч надад буйг та нар мэдэхгүй гэж үү? Мөн тэрээр тэдэнд ярихыг зарлиглав; гэвч тэд юу ч хариулсангүй.

20 Мөнхүү улиран тохиох дор тэд одож мөн өөрсдийнхөө замаар явцгаав, гэвч маргааш нь дахин ирэв; мөн шүүгч түүнчлэн тэднийг хацир дээр нь дахин цохив. Мөн түүнчлэн олон нь дөхөн очиж, мөн тэднийг цохиж, хэлрүүн: Та нар дахин босож мөн энэ хүмүүсийг шүүж, мөн хуулийг маань буруушаах уу? Хэрэв та нарт тийм их хүч буй аваас та нар

өөрсдийгөө яагаад “чөлөөлөхгүй байна?

21 Мөн тэд олон тийм зүйлийг тэдэнд хэлж, шүдээ хавирцгааж, мөн тэдний дээр нулимж, мөн хэлрүүн: Бид яллагдсан үедээ ямар харагдах бол?

22 Мөн олон тийм зүйл, тийм ээ, тэд бүх л төрлийн ийм зүйлийг тэдэнд хэлсэн болой; мөн тийн тэд олон хоногийн турш тэднийг дооглов. Мөн тэд өлсөж болохын тулд тэдэнд хүнс, мөн тэд цангаж болохын тулд ус өгөхөөс татгалзсан болой; мөн түүнчлэн хувцсыг нь тэднээс авсан учир тэд нүцгэн байв; мөн тийн тэд бөх олсоор хүлүүлж, мөн шоронд хоригдов.

23 Мөнхүү улиран тохиох дор тэд олон хоногийн турш тийн зовсны дараа, (мөн энэ нь Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арав дахь онд, аравдугаар сарын, арванхоёр дахь өдөр байв) олсоор хүлэгдсэн Алма, Амюлек нарын байгаа шоронд, Аммонайхагийн нутгийн ерөнхий шүүгч мөн тэдний багш нарын мөн тэдний хуульчдын олон нь очив.

24 Мөн ерөнхий шүүгч тэдний өмнө зогсоод, мөн тэднийг дахин цохиж, мөн тэдэнд хэлэв: Хэрэв Бурханы хүч та нарт байвал энэ хүлээснээс өөрсдийгөө чөлөөлөөч, мөн тэгвэл та нарын үгсийн дагуу Их Эзэн энэ хүмүүсийг устгах болно гэдэгт бид итгэх болно.

25 Мөнхүү улиран тохиох дор бүр сүүлчийнх нь хүртэл, тэд бүгд урагш дөхөн мөн тэднийг цохиж, нэгэн адил үгсийг хэлэв; мөн сүүлчийнх нь тэдэнд ярьсны дараа “Бурханы хүч Алма Амюлек хоёр дээр байж, мөн тэд босож мөн хөл дээрээ зогсоцгоов.

26 Мөн Алма хашгирч, хэлрүүн: Бид энэ аймшигт “зүдрэлүүдийг хэр удаан хүлцэх билээ, Ай Их Эзэн? Ай Их Эзэн, Христэд итгэх бидний итгэлийн дагуу, бүр чөлөөлөгдөх хүртэл бидэнд хүчийг өгөөч. Мөн тэд хүлэгдсэн олсоо тасчив; мөн хүмүүс үүнийг хараад, устгалаас айх айдас тэдэн дээр ирсэн учир зугтаж эхлэв.

27 Мөнхүү улиран тохиох дор тэдний айдас агуу байсан учир тэд хөсөр унаж, мөн “шоронгийн гадаах хаалганд хүрсэнгүй; мөн газар хүчтэйгээр чичирч, мөн шоронгийн хана хоёр хэсэгт хуваагдан цуурч, иймээс тэд газарт унав; мөн Алма Амюлек хоёрыг цохиж байсан ерөнхий шүүгч, мөн хуульчид, мөн санваартнууд, мөн багш нар үүний нурангид алагдав.

28 Мөн Алма, Амюлек хоёр шоронгоос гарч ирэв, мөн тэд гэмтээгүй байв; учир нь Христэд итгэх итгэлийнх нь дагуу Их Эзэн тэдэнд хүчийг соёрхсон ажээ. Мөн тэд тэр даруй шоронгоос гарч ирэв;

мөн тэд хүлээснээсээ “мултарсан байв; мөн шорон газарт нуран унасан байв, мөн дотор нь байсан бодгаль бүр, Алма Амюлек хоёроос бусад нь алагдав; мөн тэд тэр даруй хотод ирэв.

29 Эдүгээ их чимээг сонсоод хүмүүс хэсэг хэсгээрээ хамтдаа үүний шалтгааныг мэдэхээр гүйлдэж ирэв; мөн тэд Алма Амюлек хоёр шоронгоос гарч ирж буйг, мөн үүний хана газарт нурсныг хараад, тэд ихэд айж цочин, мөн Алма Амюлек хоёрын дэргэдээс бүр ямаа төлөө аван хоёр арслангаас зугтах лугаа адил зугтав; мөн тийн тэд Алма Амюлек хоёрын дэргэдээс зугтсан болой.

БҮЛЭГ 15

Алма, Амюлек хоёр, Сайдомд очиж мөн сүм байгуулав—Алма Зиезромыг анагааж, тэрээр сүмд нэгдэв—Олон нь баптисм хүртэж, мөн Сүм дэгжив—Алма Амюлек хоёр Зарахемлад очив. Ойролцоогоор мээ 81 он.

Мөнхүү улиран тохиох дор Алма, Амюлек хоёр тэр хоотоос одохыг зарлигдуулав; мөн тэд одож, мөн бүр Сайдомын нутагт хүрч ирэв; мөн болгоогтун, тэнд “Аммонай-хагийн нутгаас тэд Алмагийн үгсэд итгэснийхээ учир ⁶хөөгдөж мөн чулуугаар шидүү-

25a Алма 8:31.

26a Иаков 5:10–11;
Мозая 17:10–20;
С ба Г 121:7–8.

27a Үйлс 16:26;

Ифер 12:13.

28a Иаков 4:6;

3 Ниф. 28:19–22.

15 1a Алма 16:2–3, 9, 11.

б Алма 14:7.

лэн зайлж одсон бүх хүмүүсийг тэд олов.

2 Мөн тэд бүгдэд “эхнэр мөн хүүхдүүдэд нь юу тохиолдсоныг, мөн түүнчлэн өөрсдийнхөө талаар, мөн өөрсдийн чөлөөлөлтийн ⁶хүчний тухай тэдэнд өгүүлэв.

3 Мөн түүнчлэн Зиезром өөрийнх нь “ёс бусаас үүдсэн оюун санааны их зүдрэлээс болоод ихэд халууран Сайдомд өвчтэй хэвтэж байв, учир нь тэр Алма, Амюлек хоёрыг үгүй болсон хэмээн бодсон аж; мөн тэд өөрсдийн алдсын улмаас алагдсан хэмээн бодсон байв. Мөн энэ их нүгэл, мөн түүний бусад олон нүгэл, түүний оюуныг мултрах аргагүй, үлэмж их шаналгаатай болтол тарчилгасан болой; тиймийн тул тэрээр шатам халуунаар төөнөгдөж эхэлсэн бөлгөө.

4 Эдүгээ, Алма Амюлек хоёр Сайдомын нутагт байгааг тэрээр сонсоод, зүрх нь зоригжиж эхлэв; мөн тэднийг түүн дээр ирэхийг хүсэн, тэрээр даруй тэдэнд мэдээ илгээв.

5 Мөнхүү улиран тохиох дор тэдэнд түүний илгээсэн мэдээг даган, тэд даруйхан очив; мөн тэд гэрт нь Зиезром дээр оров; мөн тэд түүнийг орондоо өвчтэй, шатам халууран ихэд дорой байхыг нь олов; мөн түүнчлэн түүний оюун санаа алдсуудынхаа учир үлэмж шаналан байв; мөн тэрээр тэднийг хараад тэр

гараа сунгаж, мөн өөрийг нь эдгээхийг тэднээс гуйв.

6 Мөнхүү улиран тохиох дор Алма түүний гараас бариад, түүнд хэлэв: Та авралд хүргэх Христийн хүчинд “итгэдэг үү?

7 Мөн тэрээр хариулж мөн хэлсэн нь: Тийм ээ, би таны заасан бүх үгэнд итгэдэг.

8 Мөн Алма хэлсэн нь: Хэрэв та Христийн гэтэлгэлд итгэдэг бол та “эдгээгдэж чадна.

9 Мөн тэр хэлсэн нь: Тийм ээ, би таны үгсийн дагуу итгэдэг.

10 Мөн тэгээд Алма Их Эзэнд залбирч хэлрүүн: Ай Их Эзэн Бурхан минь, энэ хүнийг нигүүлсээч, мөн Христ дэх итгэлийнх нь дагуу түүнийг “эдгээгээч гэв.

11 Мөн Алма эдгээр үгсийг хэлэхэд, Зиезром хөл дээрээ “үсэрч босоод, мөн алхаж эхлэв; мөн энэ нь бүх хүмүүсийн агуу гайхашралыг төрүүлсэн аж; мөн үүний тухай мэдсэн нь бүхэл Сайдомын нутаг даяар тархав.

12 Мөн Алма Зиезромд Их Эзэнд баптисм хүртээв; мөн тэрээр тэр цагаас хойш хүмүүст номлож эхлэв.

13 Мөн Алма Сайдомын нутагт сүм байгуулан, мөн баптисм хүртэх хүсэлтэй хэнийг боловч Их Эзэний тулд баптисм хүртээх санваартнууд хийгээд багш нарыг томилон адислав.

14 Мөнхүү улиран тохиох дор тэд олон байв; учир нь тэд Сайдомын ойролцоох бүх

2а Алма 14:8–14.

б Алма 14:28.

3а Алма 14:6–7.

6а Марк 9:23.

8а су Эдгээх, Эдгэрэх.

10а Марк 2:1–12.

11а Үйлс 3:1–11.

мужуудаас цуглан ирж, мөн баптисм хүртээв.

15 Гэвч Аммонайхагийн нутагт байсан хүмүүсийн тухайд, тэд хатуу зүрх сэтгэлтэй мөн зөрүүд хүмүүс хэвээр үлдэв; мөн тэд нүглүүдээ наманчилсан нь үгүй, Алма Амюлек хоёрын бүх хүчийг чөтгөрийнх хэмээн үзэж байв; учир нь тэд “Нихорын адил бодолтой байлаа, нүглүүдийнхээ наманчлалд итгэсэнгүй.

16 Мөнхүү улиран тохиох дор, Алма Амюлек хоёр нэгэнтээ түүний найзууд асан тэд мөн түүнчлэн өөрийн эцэг мөн садангуудаараа “эсэргүүцэгдсэн учир, Бурханы үгийн төлөө Амюлек Аммонайхагийн нутагт байсан өөрийн бүх алт, мөн мөнгө, мөн өөрийн үнэт зүйлүүдээ ^борхисон ажээ;

17 Тиймийн тул, Алма Сайдомд сүм байгуулсны дараа, тэр агуу “өөрчлөлтийг харжээ, тийм ээ, хүмүүс зүрх сэтгэлийнхээ бардамналын тухайд өөрчлөгдөж, мөн өөрсдийгөө Бурханы өмнө ^бдаруусгаж эхлэн, мөн тахилын ширээний өмнө Бурханыг “бишрэн шүтэхээр, тэд Сатанаас, мөн ‘үхлээс, мөн устгалаас чөлөөлөгдөж болохын тулд үргэлжлэн ^гсэрэмжилж мөн залбирахаар өөрсдийн дугануудад өөрсдөө нэгдэн цуглаж эхэлснийг тэрээр харсны учир болой —

18 Эдүгээ миний хэлсэнчлэн,

Алма эдгээр бүх зүйлийг үзсэн тул, тиймийн тул тэрээр Амюлекийг авч мөн Зарахемлагийн нутагт ирж, мөн түүнийг өөрийн гэрт аваачин, мөн зовлон зүдгүүрт нь түүнд тусалж, мөн түүнийг Их Эзэний талаар хүчирхэгжүүлэв.

19 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арав дахь он төгсөв.

БҮЛЭГ 16

Леменчүүд Аммонайхагийн хүмүүсийг устгав — Зорам леменчүүдийг ялсан ялалтанд нифайчуудыг удирдав — Алма Амюлек хоёр мөн бусад олон нь үгийг номлов — Христ амилалтынхаа дараа нифайчуудад үзэгдэх болно хэмээн тэд заав. Ойролцоогоор мээ 81–77 он.

Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арваннэг дэх онд, хоёрдугаар сарын тав дахь өдөр, Зарахемлагийн нутагт ихэд амгалан байсны дараа, бүр арваннэгдүгээр оны хоёрдугаар сарын тав дахь өдрийг хүртэл тодорхой хэдэн жилийн турш дайнууд бас тэмцлүүд үгүй байсны дараа, уг нутаг даяар дайны зар дуулдав.

2 Учир нь болгоогтун, леменчүүдийн их цэрэг аглаг буйдын зүгээс, нутгийн хилийг

15а Алма 1:2–15.

16а су Хавчих,
Хавчлага.
б Лук 14:33;

Алма 10:4.

17а Алма 16:21.

б су Даруу, Даруу
байдал.

в су Шүтэн бишрэх.

г су Сүнсний үхэл.

д су Залбирал; Харах,
Харуул.

даван, бүр “Аммонайхагийн хотод ирж, мөн хүмүүсийг алж мөн хотыг устгаж эхэлсэн аж.

3 Мөн эдүгээ улиран тохиох дор, нифайчууд тэднийг нутгаасаа туун гаргах хангалттай их цэргийг цуглуулж чадахаас өмнө тэд Аммонайха хотод байсан хүмүүсийг мөн түүнчлэн Ноагийн хилийн ойролцоох заримыг ч “устгаж, мөн бусад заримыг олзлон аглаг буйд тийш авч явсан байв.

4 Эдүгээ улиран тохиох дор нифайчууд аглаг буйд тийш олзлогдон аваачигдсан тэднийг буцаан авахыг хүсч байв.

5 Тиймийн тул, нифайчуудын их цэргийг захирах ерөнхий ахмадаар томилогдсон, (мөн түүний нэр Зорам, мөн тэрээр Лихай, Эйха гэсэн хоёр хүүтэй байв)—эдүгээ Зорам мөн түүний хоёр хүү, Алма сүмийн дээрх дээд санваартан болохыг мэдсэн учир, мөн түүнд бошиглолын суу билэг байгааг дуулсан учир, тиймийн тул тэд түүнд очиж мөн тэднийг леменчүүдэд олзлогдсон өөрсдийн ах дүүсийг хайхаар аглаг буйд тийш хааш явахыг Их Эзэн хүсч байгааг түүнээс мэдэхийг хүсэв.

6 Мөнхүү улиран тохиох дор Алма Их Эзэнээс уг хэргийн талаар “лавлав. Мөн Алма эргэж ирээд мөн тэдэнд хэлсэн нь: Болгоогтун, леменчүүд Мантай нутгийн хилийн

цаадах, өмнөдийн аглаг буйд дахь хэсгээр Сидон голыг гатлах болно. Мөн болгоогтун Сидон голын зүүн эрэгт, тэнд та нар тэдэнтэй тулгарч, мөн тэнд Их Эзэн леменчүүдээр боолчлолд аваачигдсан ах дүүсийг тань та нарт чөлөөлж өгөх болно.

7 Мөнхүү улиран тохиох дор Зорам мөн түүний хөвгүүд, их цэрэгтэйгээ Сидон голыг гаталж, мөн Мантайн хилийн цаана Сидон голын зүүн эрэг дэх, өмнөдийн аглаг буйд тийш жагсан очив.

8 Мөн тэд леменчүүдийн их цэргийн дээр ирж, мөн леменчүүд тараагдаж мөн аглаг буйд тийш туугдав; мөн тэд леменчүүдээр олзлогдсон ах дүүсээ авч мөн олзлогдсон тэднээс нэг ч бодгаль алдагдсан нь үгүй. Мөн тэд өөрсдийн нутгуудыг эзэмшихээр ах дүүсээрээ авчрагдав.

9 Мөн леменчүүд уг нутгаас туугдаж, мөн Аммонайхагийн хүмүүс “устгагдан, шүүгчдийн арваннэгдэх он тийн төгсөв; тийм ээ, аммонайхачуудын амьд бодгаль бүхэн, мөн түүнчлэн тэдний агуу ихийнх нь учир Бурхан ч⁶устгаж чадахгүй гэсэн агуу хот нь устгагдав.

10 Гэвч болгоогтун, “нэг өдрийн дотор энэ нь эзгүйрч үлдэв; мөн үхдэл хүүрүүд нь ноход мөн аглаг буйдын зэрлэг араатнуудад урж тасчуулагдав.

16 2a Алма 15:1, 15–16.

3a Алма 9:18.

6a Алма 43:23–24.

9a Алма 8:16; 9:18–24;

Морм. 6:15–22.

б Алма 25:1–2.

10a Алма 9:4.

11 Гэсэн хэдий ч, олон хоногийн дараа тэдний цогцос нь газрын гадаргуу дээр овоологдож, мөн тэдгээр нь өнгөцхөн хучилтаар хучигдав. Мөн эдүгээ түүний үнэр хүмүүс олон жилийн турш Аммонайхагийн нутгийг эзэмшихээр явахааргүй тийм их байв. Мөн энэ нь Нихоруудын Эзгүйрэл гэж нэрлэгдэв; учир нь алагдсан тэд “Нихорын адил бодолтой байжээ; мөн тэдний нутаг эзгүйрч үлдэв.

12 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арвандөрөв дэх он болтол леменчүүд нифайчуудын эсрэг дайтахаар дахин ирсэнгүй. Мөн Нифайн хүмүүс гурван жилийн турш бүх нутаг даяар тийн үргэлжийн амар амгаланг эдлэв.

13 Мөн Алма Амюлек хоёр хүмүүст өөрсдийнх нь “ариун сүмүүд, мөн өөрсдийнх нь дуганууд, мөн түүнчлэн өөрсдийн нь ^бсинагогуудад иудейчүүдийн маягаар баригдсан тэдгээрт наманчлалыг номлосоор явав.

14 Мөн тэдний үгсийг сонсох тэр болгонд, үргэлж, “ямар хүн байхаас нь эс хамааран тэдэнд Бурханы үгийг тэд түгээж байв.

15 Мөн тийн Алма Амюлек хоёр, мөн түүнчлэн уг ажилд сонгогдсон өөр олон нь, бүх нутаг даяар үгийг номлохоор

явав. Мөн сүмийн байгуулалт уг нутаг даяар эргэн тойрны газар болгонд нифайчуудын бүх хүмүүсийн дунд өргөн тархсан байлаа.

16 Мөн тэдний дунд “тэгш бус байдал байсангүй; түүний ирэлтийн үед тэдний дунд заагдах үгийг хүлээн авахад хүмүүний үрсийн оюуныг бэлтгэхээр, өөрөөр хэлбэл тэдний ^бзүрх сэтгэлийг бэлтгэхээр Их Эзэн өөрийн Сүнсийг уг нутгийн бүх гадаргуу дээр юүлсэн болой—

17 Тэд үгийн эсрэг хатуурхахгүй байж болохын тулд, тэд итгэлгүйгээр үл байж, мөн устгал тийш одохгүй байж болохын тулд, харин тэд үгийг баяртайгаар хүлээн авч, мөн “мөчир адил үнэн ^бороонгод залгагдаж болохын тулд, тэд Их Эзэн Бурханыхаа “амралтад орж болохын тулд болой.

18 Эдүгээ хүмүүсийн дунд одсон “санваартнууд бүх худал, мөн ^бзаль мэхүүд, мөн “атаа жөтөө, мөн маргаан мэтгэлцээн, мөн өс хонзон, мөн доромжлолууд, мөн хулгай, дээрэм, тонуул, аллага, садар самууныг үйлдэх хийгээд бүхэл төрлийн шунаг тачаангуй байдлын эсрэг, эдгээр зүйл ийм байх ёсгүй хэмээн хашгиран номлов—

19 Удахгүй ирэх ёстой тэр зүйлийг номлож, тийм ээ,

11a Алма 1:15; 24:28–30.

13a 2 Ниф. 5:16.

б Алма 21:4–6, 20.

14a Алма 1:30.

16a Мозая 18:19–29;

4 Ниф. 1:3.

б су Харууссан зүрх.

17a Иаков 5:24.

б су Их Эзний талбай.

в Алма 12:37; 13:10–13.

18a Алма 15:13.

б су Заль, Залилах, Залилан.

в су Атаархал.

Бурханы Хүүгийн “ирэлтийг, түүний зүдгүүрүүд хийгээд үхлийг мөн түүнчлэн нас барагсдын амилуулалтыг номлов.

20 Мөн хүмүүсийн олон нь Бурханы Хүүгийн ирэх ёстой тэр газар нь хаана болохыг лавлав; мөн тэрээр өөрийн “амилалтын дараа тэдэн дээр ^бхүрч ирэх болно хэмээн тэд заалгасан ажгуу; мөн үүнийг хүмүүс агуу их баясал мөн баяртайгаар сонссон болой.

21 Мөн эдүгээ уг сүм нутаг даяар байгуулагдсаны дараа—чөтгөрийг ялах “ялалтыг үзсэн байв, мөн Бурханы үг цэвэр ариун байдлаараа бүх нутагт номлогдож, мөн Их Эзэн адислалуудаа хүмүүсийн дээр юүлсээр байв—Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арвандөрөв дэх он тийн төгсөв.

Бурханы үгийн төлөө хаант улсыг захирах эрхээсээ татгалзаж, мөн леменчүүдэд номлохоор Нифайн нутаг өөд одсон Мозаягийн хөвгүүдийн шастир; тэдний зүдгүүрүүд мөн чөлөөлөлт—Алмагийн цэдгийн дагуу оршвой.

17-гоос 27 дугаар бүлэгт агуулагдав.

БҮЛЭГ 17

Мозаягийн хөвгүүдэд бошигло-

лын хийгээд илчлэлтийн суу билэг байв—Тэд леменчүүдэд үгийг тунхаглахаар өөр өөрсдийн замаар одов—Аммон Ишмэлийн нутагт очиж мөн хаан Лемонайн зарц болов—Аммон хааны сүргийг аварч мөн Себасын усны дэргэд түүний дайснуудыг хөнөөв. 1–3 дугаар хэсэг, ойролцоогоор мээ 77 он; 4 дүгээр хэсэг, ойролцоогоор мээ 91–77 он; мөн 5–39 дүгээр хэсэг, ойролцоогоор мээ 91 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Алма Гидеоны нутгаас урагш Мантайн нутгийн зүг аялж байх зуураа, болгоогтун, түүний гайхашралыг төрүүлсэн нь, тэрээр Зарахемлагийн нутгийн зүг аялан яваа “Мозаягийн хөвгүүдтэй ^бдайралдав.

2 Эдүгээ тэнгэр элч түүнд “анх үзэгдсэн тэр цагт Мозаягийн энэ хөвгүүд Алматай хамт байжээ; тиймийн тул Алма ах дүүсээ хараад үлэмж баярлав; мөн түүний баяр хөөрийг илүүгээр нэмсэн нь, тэд Их Эзэний хувьд түүний ах дүүс хэвээрээ байсны учир болой; тийм ээ, мөн тэд үнэний мэдлэгт хүчтэй болсон байв; учир нь тэд зөв ойлголттой хүмүүс мөн тэд Бурханы үгийг мэдэж болохын тулд судруудыг хичээнгүйлэн ^бсудалсан байв.

3 Гэвч энэ нь бүгд бус; тэд өөрсдийгөө их залбирал, мөн

19а су Есүс Христ—
Есүс Христийн
төрөлт болон нас
баралтын тухай
бошиглол.

20а 2 Ниф. 26:9;
3 Ниф. 11:7–14.
б 1 Ниф. 12:4–6.
21а Алма 15:17.
17 1а Мозая 27:34.

б Алма 27:16.
2а Мозая 27:11–17.
б су Судрууд.

“мацаг барилтанд зориулсан байв; тиймийн тул тэдэнд бошиглолын суу билэг, мөн илчлэлтийн суу билэг байлаа, мөн тэд ^азааж байхдаа Бурханаас хүлээн авсан хүч мөн эрх мэдэлтэйгээр тэд зааж байв.

4 Мөн тэд леменчүүдийн дунд арвандөрвөн жилийн турш Бурханы үгийг зааж, олныг үнэний мэдлэгт ^аавчрахдаа их ^бамжилттай байв; тийм ээ, тэдний үгсийн хүчээр Бурханы тахилын ширээний өмнө, түүний нэрийг дуудаж мөн түүний өмнө нүглүүдээ ^ахүлээхээр олон нь авчрагдсан бөлгөө.

5 Эдүгээ тэдний аяллын үед тэдэнд тохиолдсон нөхцөл нь эдгээр болой, учир нь, тэдэнд олон зүдрэл байв; тэд өлсөж, цанган мөн ядрах мэтээр биеэрээ ч мөн оюунаараа ч аль алинаар нь ихэд зовж, мөн түүнчлэн сүнсээрээ ихэд ^ахөдөлмөрлөв.

6 Эдүгээ эдгээр нь тэдний аянууд байв: Шүүгчдийн эхний жилд, өөрсдийн эцэг, Мозаятай, тэд ^асалах ёс гүйцэтгэсний дараа; эцэг нь тэдний дээр шилжүүлэхийг хүссэн хаант улсаас ^бтатгалзсаны дараа, мөн түүнчлэн энэ нь хүмүүсийн бодол байв;

7 Гэсэн хэдий ч тэд Зарахемлагийн нутгаас одож, мөн

өөрсдийн илд, мөн өөрсдийн жад, мөн өөрсдийн нум, мөн өөрсдийн сум, мөн өөрсдийн дүүгүүрүүдийг авчээ; мөн аглаг буйдад байх зуураа өөрсөддөө хүнс залгуулж болохын тулд тэд үүнийг хийсэн болой.

8 Мөн тийн тэд өөрсдийн сонгосон хэдтэйгээ Нифайн нутаг өөд явж, Бурханы үгийг леменчүүдэд номлохоор аглаг буйд тийш одов.

9 Мөнхүү улиран тохиох дор тэд аглаг буйдад олон хоног аялж, мөн хэрэв энэ нь боломжтой аваас өөрсдийн ах дүүс, леменчүүдийг үнэний мэдлэгт, зөв бус байсан тэр эцэг өвгөдийнх нь ^ауламжлалуудын дорд байдлын тухай мэдлэгт авчрахад Бурханы мутарт ^бзэмсэг болж болохын тулд, тэдэнтэй хамт явж, мөн тэдэнтэй оршин байх өөрийн Сүнсний хэсгийг Их Эзэн тэдэнд соёрхоосой хэмээн тэд ихэд мацаг барьж мөн ихэд ^азалбирав.

10 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн өөрийн ^аСүнсээр тэдэнд ^бзочилж, мөн тэдэнд: ^аТайтгарагтун хэмээв. Мөн тэд тайтгарцгаав.

11 Мөн Их Эзэн тэдэнд түүнчлэн хэлсэн нь: Өөрсдийн ах дүүс леменчүүдийн дунд явж, мөн миний үгийг

3а су Мацаг барих,
Мацаг барилт;
Залбирал.

б су Зааж,
Багш—Сүнсээр
зааж.

4а Алма 29:14.

б су Номлолын ажил.

в су Хүлээн
зөвшөөрөх, Хүлээн
зөвшөөрөлт.

5а Алма 8:10.

6а Мозая 28:1, 5–9.

б Мозая 29:3.

9а Алма 3:10–12.

б Мозая 23:10;

Алма 26:3.

в Алма 25:17.

су Залбирал.

10а С ба Г 5:16.

б су Ариун Сүнс.

в Алма 26:27.

тогтоо; хэдий тийм ч та нар зовлонгууд мөн зүдрэлүүддээ “тэвчээртэй байх болно, та нар надаар дамжуулж сайн үлгэр жишээг тэдэнд үзүүлж болохын тул болой, мөн олон бодгалийн авралын төлөө би та нарыг өөрийн мутар дахь зэмсэг болгох болно.

12 Мөнхүү улиран тохиох дор Мозаягийн хөвгүүдийн, мөн түүнчлэн тэдэнтэй байсан тэдний зүрх сэтгэл ч бас, Бурханы үгийг тэдэнд тунхаглахаар леменчүүдэд очих зоригийг олов.

13 Мөнхүү улиран тохиох дор тэд леменчүүдийн нутгийн хилд хүрч ирээд, тэд өөрсдөө “хуваагдаж мөн тэд ^бургацаа хураасны эцэст дахин уулзах болно хэмээн Их Эзэнд итгэн нэг нэгнээсээ салцгаав; учир нь тэдний хүлээсэн ажил агууг ухаарсан ажгуу.

14 Мөн энэ нь лавтайяа агуу их зүйл байв, учир нь тэд Бурханы үгийг “зэрлэг мөн хатуу сэтгэлт мөн харгис хүмүүст; нифайчуудыг хөнөөхдөө, мөн тэднийг дээрэмдэж мөн тонохдоо баясдаг хүмүүст номлох үүргийг хүлээн авчээ; мөн тэдний зүрх сэтгэл баялгууд, өөрөөр хэлбэл алт мөн мөнгөн дээр мөн үнэт чулуунууд дээр байрласан байлаа; хэдий тийм ч тэд өөрсдийнхөө төлөө өөрсдийн гараар хөдөлмөрлөхгүй байж болохын тулд тэд эдгээр зүйлийг

аллагаар мөн тонуулаар олж авахыг эрэлхийлдэг байв.

15 Наманчлалын нөхцөл дор Их Эзэний амлалтууд тэдэнд боломжтой болсон хэдий ч тэд тийн маш залхаг хүмүүс байв, олон нь хиймэл шүтээнүүдийг биширч, мөн тэдний эцэг өвгөдийн “уламжлалуудын учир Бурханы “зүхэл тэдний дээр буусан ажээ.

16 Тиймийн тул, энэ нь тэднийг наманчлалд авчирч магад хэмээн, Мозаягийн хөвгүүд уг ажлыг хийхээр хүлээсний “шалтгаан байв; тэд гэтэлгэлийн төлөвлөгөөний талаар тэдэнд мэдүүлж болох магад хэмээсний учир бөлгөө.

17 Тиймийн тул тэд өөрсдөө нэг нэгнээсээ салцгааж, мөн хүн бүр ганцаараа түүнд өгөгдсөн Бурханы үг болон хүчний дагуу тэдний дунд одов.

18 Эдүгээ Аммон тэдний дунд ахлагч нь байв, өөрөөр хэлбэл тэдэнд зааварладаг байжээ, мөн тэрээр тэдний хэд хэдэн албан тушаалынх нь дагуу тэднийг “адисалсны дараа, Бурханы үгийг тэдэнд хэлснийхээ дараа, өөрөөр хэлбэл явахынхаа өмнө тэдэнд зааварласныхаа дараа тэднээс салж одов; мөн тийн тэд уг нутаг даяар тус тусын аяныг хөөв.

19 Мөн Аммон, түүнчлэн леменчүүд болсон Ишмэилийн

11a Алма 20:29.
су Тэвчээр.
13a Алма 21:1.
б Мат. 9:37.

14a Мозая 10:12.
15a Алма 9:16–24; 18:5.
б Алма 3:6–19;
3 Ниф. 2:15–16.

16a Мозая 28:1–3.
18a су Адислах,
Адислагдах,
Адислал.

“хөвгүүдийн нэрээр нэрлэгдсэн нутаг болох Ишмэилийн нутагт очив.

20 Мөн Аммон Ишмэилийн нутагт ормогц, түүнийг, тэдний гарт орсон нифайчуудыг хүлж, мөн хааны өмнө тэднийг аваачдаг заншлаараа леменчүүд түүнийг баривчилж мөн түүнийг хүлэв; мөн тийн тэднийг алах, эсвээс тэднийг боолчлолд байлгах, эсвээс тэднийг шоронд хорих, эсвээс тэднийг нутгаасаа гарган хаях нь хааны таалалд, түүний хүсэл мөн тааллын дагуу үлддэг байв.

21 Мөн тийн Аммон Ишмэилийн нутгийг захирсан хааны өмнө хүргэгдэв; мөн түүний нэр Лемонай байв; мөн тэрээр Ишмэилийн удмынх байжээ.

22 Мөн хаан Аммоноос тэрээр уг нутагт леменчүүдийн дунд, өөрөөр хэлбэл түүний хүмүүсийн дунд орших хүсэлтэй эсэхийг лавласан ажгуу.

23 Мөн Аммон түүнд хэлэв: Тийм ээ, би хэсэг хугацаанд хүсэлтэй; би хэсэг хугацаанд; магадгүй үхэх өдрөө хүртэл энэ хүмүүсийн дунд орших хүсэлтэй хэмээв.

24 Мөнхүү улиран тохиох дор Лемонай хаан Аммоныг таалан үзэж, мөн түүний хүлээсийг тайлах болгов; мөн тэрээр Аммон өөрийнх нь окидоос нэгийг нь эхнэр болгон аваасай хэмээн хүсэв.

25 Харин Аммон түүнд хэлэв: Үгүй, харин би таны зарц

байх болно. Тиймийн тул Аммон, Лемонай хааны зарц болов. Мөнхүү улиран тохиох дор тэрээр леменчүүдийн заншлын дагуу Лемонайн сүргийг хариулахаар бусад зарим зарц нарын дунд байрлуулагдав.

26 Мөн тэрээр хааны үйлчлэлд гурав хоног байсны дараа, тэрээр лемен үндэсний зарц нартай хамт сүргийг авч Себасын ус гэж нэрлэгдсэн устай газарт очиход нь, мөн бүх леменчүүд тэдгээр нь ус ууж болно хэмээн сүргээ тийш туун очжээ—

27 Тиймийн тул, Аммон болон хааны зарц нар сүргээ энэ устай газрын зүг тууж явтал, болгоогтун, малаа усалж байсан тодорхой тооны леменчүүд босож мөн Аммоны болон хааны зарц нарын сүргийг тарааж, мөн тэдгээр нь тал тал тийш зугтах хүртэл нь тэдгээрийг тараав.

28 Эдүгээ хааны зарц нар бувтналдаж эхлэв, хэлсэн нь: Эдүгээ сүрэг нь эдгээр эрчүүдээр ёс бусаар тараагдсан учир бидний ах дүүсийг тэгсэн шигээ, хаан биднийг алах болно. Мөн тэд үлэмж ихээр уйлж эхлэн, өгүүлсэн нь: Болгоогтун, бидний сүрэг аль хэдийн тараагдсан.

29 Эдүгээ тэд алагдахаас айсны учир уйлжээ. Эдүгээ Аммон үүнийг хараад дотроо зүрх сэтгэл нь баяраар бялхав; учир нь, тэр хэлэв, энэ сүргийг хаанд эргүүлэн өгснөөр би өөрийн хүчийг, өөрөөрхэл-

бэл надад буй тэр хүчийг, эдгээр бусад зарц нарт үзүүлэх болно, би эдгээр бусад зарц нарын сэтгэлийг татаж болохын тулд, тэднийг үгсэд минь итгэхэд би удирдаж болохын тулд буюу.

30 Мөн эдүгээ, тэрээр өөрийн ах дүүс гэж нэрлэсэн тэдний зовлонг хараад бодсон Аммоны бодол нь эдгээр байв.

31 Мөнхүү улиран тохиох дор тэрээр өөрийн үгсээр тэднийг зоригжуулж, хэлсэн нь: Ах дүүс минь, урамтай байцгаа мөн сүргийг эрэхээр явцгаая, мөн бид тэдгээрийг цуглуулж бас тэдгээрийг устай газар буцаан авчрах болно; мөн тийн бид хаанд сүргийг нь хадгалан хамгаалж тэгснээр тэр биднийг алахгүй байх болно.

32 Мөнхүү улиран тохиох дор тэд сүргийг хайн явж, мөн тэд Аммоныг даган, мөн тэд их хурднаар яаран явж мөн хааны сүргийг тогтоож, мөн тэдгээрийг дахин устай газар нэгтгэн цуглуулав.

33 Мөн сайхь эрчүүд тэдний сүргийг тараахаар дахин босож ирэв; гэвч Аммон ах дүүстээ хэлсэн нь: Зугтаалгахгүйн тул сүргийг тойрон хүрээл; мөн би явж мөн бидний сүргийг тараасан эдгээр эрчүүдтэй тэмцэлдье.

34 Тиймийн тул, тэд Аммон өөрсдөд нь зарлигласныг хийж, мөн тэрээр урагш одож мөн Себасын усны дэргэд зогсоцгоож байсан тэдэнтэй

тэмцэлдэхээр зогсов; мөн тэд тоогоороо цөөн байсангүй.

35 Тиймийн тул тэд Аммо-наас айсангүй, учир нь эрчүүдийн нэг нь тэдний хүслийн дагуу түүнийг алж чадна хэмээн тэд боджээ, учир нь тэрээр хөвгүүдийг нь тэдний гараас “чөлөөлнө хэмээн Их Эзэн Мозаяд амласныг тэд мэдсэнгүй; бас Их Эзэний талаар юу ч эс мэдэх ажээ; тиймийн тул тэд ах дүүсийнхээ устгалд баясдаг байв; мөн үүнийхээ улмаас тэд хааны сүргийг тараахаар босоцгоосон аж.

36 Гэвч “Аммон босож мөн дүүгүүрээрээ тэдэн рүү чулуу нүүлгэж эхлэв; тийм ээ, их хүчтэйгээр чулууг тэдний дунд тэр дүүгүүрдэж байв; мөн тийн тэрээр тэдний “хэд хэдийг алсан учир, үүний хэрээр тэд түүний хүчийг гайхан бахдаж эхлэв; гэсэн хэдий ч тэд ах дүүс нь алуулсан учир ууртай байв, мөн тэд түүнийг унах ёстой хэмээн хатуу шийдсэн байв; тиймийн тул, тэд түүнийг чулуугаар “онож чадахгүй байгаагаа хараад, бороохой шийдэмтэйгээр түүнийг алахаар тэд давшин ирэв.

37 Гэвч болгоогтун, Аммоныг цохихоор шийдмээ өргөсөн хүн бүрийг, тэрээр илдээрээ гарыг нь тас цавчив; тодруулбал тэр илднийхээ ирээр тэдний гарыг цавчин тэдний дайралтуудыг эсэргүүцэж, үүний хэрээр тэд гайхан

цочирдож эхлэв, мөн түүнээс зугтаж эхлэв; тийм ээ, мөн тэд цөөн тоотой байсангүй; мөн тэрээр гарынхаа хүчээр тэднийг зугтахад хүргэв.

38 Эдүгээ тэдний зургаа нь дүүгүүрт унасан байлаа, харин тэр тэдний удирдагчаас нь өөр хэнийг ч илдээрээ алсан нь үгүй; мөн тэр түүний эсрэг далайсан тэр болгоны гарыг тас цавчсан аж, мөн тэд цөөн байгаагүй билээ.

39 Мөн тэрээр тэднийг хол хөөгөөд, тэр эргэж ирэв, мөн тэд сүргээ усалж мөн тэдгээрийг хааны бэлчээрт эргүүлж аваачаад, тэгээд хаанд очиж, түүнийг хөнөөхийг эрэлхийлсэн тэдний, Аммоны илдээр тас цавчигдсан, гаруудыг үзүүлэв; мөн тэдний хийсэн зүйлүүдийн гэрч болгон хаанд тэдгээр нь авчрагдав.

БҮЛЭГ 18

Хаан Лемонай, Аммоныг Агуу Их Сүнс хэмээн бодов—Аммон Бүтээлийн тухай, Бурханы хүмүүнтэй үйлдэх хэргүүдийн тухай, мөн Христээр дамжин ирэх гэтэлгэлийн тухай хаанд заав—Лемонай итгэж мөн үхсэн мэт газар унав. Ойролцоогоор мээ 90 он.

Мөнхүү улиран тохиох дор Лемонай хаан өөрийн зарц нарыг урагшилж, уг хэргийн талаар харсан бүх зүйлийг гэрчлэх болгов.

2 Мөн тэд бүгд өөрсдийн

харсан зүйлийг гэрчлээд, мөн тэрээр Аммон түүний сүргийг хадгалан хамгаалахад итгэлтэйг нь, мөн түүнчлэн түүнийг алахаар эрэлхийлсэн тэдний эсрэг тэмцэлдэхэд түүний агуу хүчийг мэдсэний дараа, тэрээр үлэмж гайхан балмагдаж, мөн хэлэв: Энэ бол хүнээс нэт нь гарцаагүй юм. Болгоогтун, тэдний аллагуудын учир агуу шийтгэлүүдийг энэ хүмүүсийн дээр илгээдэг Агуу Их Сүнс нь энэ бус уу?

3 Мөн тэд хаанд хариулж, мөн хэлэв: Тэрээр Агуу Их Сүнс үү эсвэл хүн үү гэдгийг бид мэдэхгүй; харин бидний мэдэх нь, тэр хааны дайснуудад “алагдахгүй; бас тэр бидэнтэй байхад хааны сүргийг тэд тарааж чадахгүй, түүний чадвар болоод агуу хүчний учир буюу; тиймийн тул, тэр бол хааны анд гэдгийг бид мэднэ. Мөн эдүгээ, Ай хаантан, хүнд тийм агуу хүч байдагт бид итгэдэггүй, учир нь тэр алагдахгүйг бид мэднэ.

4 Мөн эдүгээ, хаан эдгээр үгийг дуулаад, тэрээр тэдэнд хэлэв: Эдүгээ энэ бол Агуу Их Сүнс мөн гэдгийг би мэдлээ; мөн энэ үед би та нарыг ах дүүсийн чинь адил “алахгүй байж болохын тулд та нарын амийг хамгаалахаар тэрээр бууж иржээ. Эдүгээ энэ нь бидний эцэг өвгөдийн ярьсан Агуу Их Сүнс болой.

5 Эдүгээ “Агуу Их Сүнс байдаг гэдэг нь эцгээсээ хүлээн

авсан Лемонайн уламжлал байв. Агуу Их Сүнсэнд тэд итгэсэн хэдий ч, тэд ямар ч юм хийсэн тэдний зөв хэмээн бодсон ажээ; гэсэн хэдий ч, Лемонай, зарц нараа алахдаа бурууг үйлдсэн болов уу хэмээх айдсаар үлэмж ихээр айж эхлэв;

6 Учир нь тэдний ах дүүс устай газар тэдний сүргүүдийг тараасан учир тэрээр тэднээс олныг алсан байв; мөн тийн, тэд сүргээ тараалгасан учир тэд алагджээ.

7 Эдүгээ Себасын усны дэргэд хүмүүсийн сүргийг тараахаар, тэгснээрээ тэд тараагдсанаас олныг нь нутагтаа тууж болохын тулд зогсдог нь эдгээр леменчүүдийн зуршил байв, учир нь тэдний дунд ингэж тонуул хийх нь зуршил болсон байлаа.

8 Мөнхүү улиран тохиох дор Лемонай хаан зарц нараасаа лавлаж, өгүүлсэн нь: Тийм агуу хүчтэй тэр хүн хаана байна?

9 Мөн тэд түүнд хэлэв: Болгоогтун, тэр таны морьдыг тэжээж байна. Эдүгээ хаан зарц нартаа сүргийг нь услахаас урьд тэд морьдыг нь мөн сүйх тэрэгнүүдийг нь бэлтгэж мөн Нифайн нутагт хүргэж өгөхийг зарлигласан байв; учир нь бүх нутгийг захирах хаан болох Лемонайн эцгээр, Нифайн нутагт их хурим болох нь товлогдсон ажээ.

10 Эдүгээ Аммон түүний морьд мөн түүний сүйх тэргүүдийг бэлтгэж буйг хаан Лемонай сонсоод, Аммоны

итгэлтэйн учир тэр илүүтэй ихээр гайхан балмагдсан байж, хэлрүүн: Энэ хүний адил ийм итгэлтэй зарц миний бүх зарц нарын дунд байгаагүй нь гарцаагүй; тодруулбал тэрээр бүр миний бүх зарлигуудыг, тэдгээрийг гүйцэлдүүлэхээ санадаг.

11 Эдүгээ энэ бол Агуу Их Сүнс гэдгийг би гарцаагүй мэдлээ, мөн би түүнийг над дээр ирэхийг хүсэх сэн, гэвч би зүрхлэхгүй байна.

12 Мөнхүү улиран тохиох дор Аммон морьдыг мөн сүйх тэргүүдийг хаанд мөн түүний зарц нарт бэлэн болгоод, тэрээр хаанд очиж, мөн тэрээр хааны царай төрх өөрчлөгдсөнийг харав; тиймийн тул тэрээр түүний дэргэдээс холдон буцахыг завдав.

13 Мөн хааны зарц нарын нэг нь түүнд Раббана хэмээж, тэр нь хөрвүүлбээс хүчит эсвээс агуу их хаан гэсэн утгатай, учир нь тэд өөрсдийн хаадыг хүчит хэмээн үздэг байв; мөн тэрээр түүнд тийн хэлэв: Раббана, хаан таныг үлдэхийг хүснэ.

14 Тиймийн тул Аммон хааны зүг эргэж мөн түүнд хэлэв: Ай хаантан, та намайг таны төлөө юу хийхийг хүснэв? Мөн тэдний цагийн хэмжүүрийн дагуу нэг цагийн турш хаан түүнд хариулсангүй, учир нь тэр түүнд юу хэлэх ёстойгоо мэдсэнгүй.

15 Мөнхүү улиран тохиох дор Аммон түүнд дахин хэлэв: Та надаас юу хүснэв? Гэвч хаан түүнд хариулсангүй.

16 Мөнхүү улиран тохиох дор Аммон, Бурханы Сүнсээр дүүргэгдсэн учир, тиймийн тул тэр хааны “бодлуудыг мэдэрсэн болой. Мөн тэрээр түүнд хэлэв: Та намайг таны зарц нар болон таны сүргийг хамгаалсан, таны мал мөн таны зарц нарыг хамгаалахын тул, тэдний ах дүүсийн долоог нь дүүгүүр болон илдээр алж, мөн бусдынх нь гарыг тас цохьсоныг дуулсны учир буюу; болгоогтун, таны гайхлыг төрүүлсэн нь энэ үү?

17 Би танд хэлнэ, юу нь таны гайхлыг ийм ихээр төрүүлсэн билээ? Болгоогтун, би бол хүн, мөн таны зарц билээ; тиймийн тул, таны хүссэн зөв юуг боловч, би түүнийг хийх болно.

18 Эдүгээ хаан энэ үгсийг дуулаад, тэрээр дахин гайхав, учир нь Аммон түүний бодлуудыг “мэдэж чадсаныг болгоов; гэвч энэ нь болсон хэдий ч Лемонай хаан амаа нээж, мөн түүнд хэлэв: Та хэн билээ? Та бүх зүйлийг “мэддэг Агуу Их Сүнс мөн үү?

19 Аммон хариулж мөн түүнд хэлэв: Би биш.

20 Мөн хаан хэлэв: Та яаж миний зүрхний бодлуудыг мэдэв? Та зоригтойгоор ярьж болно, мөн энэ зүйлүүдийн талаар надад хэлж болно; мөн түүнчлэн та ямар хүчээр миний сүргийг тараасан ах дүүсийг минь алж мөн гарыг нь тас цавчсан билээ—

21 Мөн эдүгээ, хэрэв та энэ

зүйлүүдийн талаар надад хэлэх аваас, таны хүссэн юуг боловч би танд өгнө; мөн хэрэв энэ нь хэрэгтэй бол, би таныг өөрийн их цэргээр сахиулъя; гэвч та бол тэд бүгдээс илүү хүчтэйг би мэднэ; гэсэн хэдий ч, надаас таны хүссэн юуг боловч би танд зөвшөөрөх болно.

22 Эдүгээ Аммон зальжин нэгэн; гэвч гэмгүй байсан тул, тэр Лемонайд хэлэв: Хэрэв би ямар хүчээр энэ зүйлийг хийснээ хэлбэл, та миний үгсийг анхааран сонсох уу? Мөн энэ нь танаас миний хүсэх тэр зүйл ажгуу.

23 Мөн хаан түүнд хариулж, мөн хэлэв: Тийм ээ, би таны бүх л үгсэд итгэнэ, мөн тийн тэрээр заль мэхэнд нь автагдсан байв.

24 Мөн Аммон “зоригтойгоор түүнд ярьж эхлэв, мөн түүнд хэлсэн нь: Та Бурхан байдагт итгэдэг үү?

25 Мөн тэр хариулж, мөн түүнд хэлэв: Тэр нь ямар утгатайг би мэдэхгүй.

26 Мөн тэгэхэд нь Аммон хэлэв: Агуу Их Сүнс байдагт та итгэдэг үү?

27 Мөн тэр хэлсэн нь, Тийм ээ.

28 Мөн Аммон хэлсэн нь: Энэ бол Бурхан. Мөн Аммон түүнд дахин хэлэв: Бурхан болох тэр Агуу Их Сүнс тэнгэр мөн газарт байдаг бүх зүйлийг бүтээсэн гэдэгт та итгэдэг үү?

29 Мөн тэрээр хэлэв: Тийм ээ, газарт буй тэр бүхий л

зүйлийг тэр бүтээсэн гэдэгт би итгэдэг; гэвч би тэнгэрийн тухайд мэдэхгүй.

30 Мөн Аммон түүнд хэлсэн нь: Тэнгэр гэдэг нь Бурхан мөн түүний бүх ариун тэнгэр элчүүд оршдог тэр газар бөлгөө.

31 Мөн Лемонай хаан хэлэв: Энэ нь газраас дээгүүр байдаг уу?

32 Мөн Аммон хэлэв: Тийм ээ, мөн тэрээр бүх хүмүүний үрсийн дээрээс доош хардаг; мөн тэр бүх зүрхний “бодлууд хийгээд санааг мэддэг; учир нь тэд бүгд эхлэлээс түүний мутраар бүтээгдсэн ажгуу.

33 Мөн Лемонай хаан хэлэв: Би таны ярьсан эдгээр зүйлд итгэлээ. Та Бурханаас илгээгдсэн үү?

34 Аммон түүнд хэлэв: Би бол хүн; мөн “хүмүүн нь эхлэлд Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн, мөн би бол энэ хүмүүст эдгээр зүйлийг “заахаар түүний Ариун Сүнсээр дуудагдсан, тэд шударга бөгөөд үнэн болох тэрхүү мэдлэгт авчрагдаж болохын тулд болой;

35 Мөн “мэдлэгийг, мөн түүнчлэн Бурханы талаарх миний итгэл хийгээд хүслийн дагуу хүчийг надад өгдөг “Сүнсний хэсэг нь надад оршдог.

36 Эдүгээ Аммон эдгээр

үгсийг хэлээд дэлхийн бүтээлт, мөн түүнчлэн Адамын бүтээлтээс эхэлж, мөн түүнд хүмүүний уналтын талаар бүх зүйлийг хэлж, мөн “бошиглогчдоор яригдсан хүмүүсийн цэдгүүд болон ариун ^бсудруудыг, бүр тэдний эцэг, Иерусалимыг орхисон Лихайн цагийг хүртэлх тэдгээрийг “өгүүлж мөн түүний өмнө дэлгэжээ.

37 Мөн тэрээр тэдэнд (тухайлбал хаанд болоод түүний зарц нарт) тэдний эцэг өвгөдийн аглаг буйд дахь бүх аянуудыг, мөн тэдний бүх өлсөж мөн цангасан зовлонгууд, мөн тэдний зүдрэлүүд гэх мэтийг, мөн тийн цааш өгүүлсэн ажгуу.

38 Мөн түүнчлэн тэр Лемон болон Лемүелийн мөн Ишмэилийн хөвгүүдийн эсэргүүцлүүдийн талаар тэдэнд тоочиж, тийм ээ, тэдний бүх эсэргүүцлийг тэрээр тэдэнд өгүүлэв; мөн Лихай Иерусалимыг орхисон цагаас одоо цагийг хүртэлх бүх цэдгүүд болон судруудыг тэр тэдэнд тайлбарлав.

39 Гэвч энэ нь бүгд бус; учир нь тэр тэдэнд дэлхийн үүслээс бэлтгэгдсэн, “гэтэлгэлийн төлөвлөгөөг тайлбарлав; мөн түүнчлэн Христийн ирэлтийн талаар тэр тэдэнд мэдүүлж, мөн Их Эзэний бүх ажлыг тэрээр тэдэнд мэдүүлэв.

32a Амос 4:13;
3 Ниф. 28:6;
С ба Г 6:16.

34a Мозая 7:27;
Ифер 3:13–16.
б су Заах, Багш—

Сүнсээр заах.
35a су Мэдлэг.
б су Сүнсний
удирдамж,
Сүнслэгээр
нөлөөлөгдөх.

36a Үйлс 3:18–21.
б су Судрууд.
в Мозая 1:4;
Алма 22:12; 37:9.
39a су Гэтэлгэлийн
төлөвлөгөө.

40 Мөнхүү улиран тохиох дор тэр эдгээр бүх зүйлийг хэлсний, мөн тэдгээрийг хаанд тайлбарласны дараа, хаан түүний бүх үгэнд итгэсэн аж.

41 Мөн тэрээр Их Эзэнд залбирч эхлэн, хэлсэн нь: Ай Их Эзэн, “нигүүлсэж соёрхоно уу; Нифайн хүмүүсийн дээр байсан өөрийн өгөөмөр их нигүүлслийнхээ дагуу, надад, мөн миний хүмүүсийн дээр соёрхоно уу.

42 Мөн эдүгээ, тэрээр үүнийг хэлээд тэрээр үхсэн мэт газар унав.

43 Мөнхүү улиран тохиох дор түүний зарц нар түүнийг авч эхнэрт нь хүргэж, мөн орон дээр хэвтүүлэв; мөн тэрээр хоёр өдөр мөн хоёр шөнийн турш үхсэн мэт хэвтэв; мөн леменчүүдийн маягаар, түүнийг алдсанаас асар ихээр гашуудан эхнэр нь мөн хөвгүүд нь мөн охид нь түүнийг дээр гашуудаж байв.

БҮЛЭГ 19

Лемонай үүрдийн амьдралын гэрлийг хүлээн авч мөн Гэтэлгэгчийг харав—Түүний гэрийнхэн зүүдээр зорчих байдалд унаж, мөн олон нь тэнгэр элчүүдийг харав—Аммон гайхамшигтайгаар хадгалагдан хамгаалагдав—Тэрээр олонд баптисм хүртээж мөн тэдний дунд сүм байгуулав. Ойролцоогоор мээ 90 он.

Мөнхүү улиран тохиох дор

хоёр өдөр мөн хоёр шөнийн дараа тэд түүний биеийг авч мөн үхэгсдээ оршуулах зорилгын тулд тэдний хийсэн хадан булшинд хэвтүүлэх гэж байв.

2 Эдүгээ хатан Аммоны алдрыг сонссон тул, тиймийн тул тэр түүнийг өөр дээрээ ирэхийг хүсэн хүн илгээв.

3 Мөнхүү улиран тохиох дор Аммон зарлиглуулсныхаа дагуу явж, мөн хатанд очиж, мөн түүгээр юу хийлгэх гэснийг тэр мэдэхийг хүсэв.

4 Мөн тэрээр түүнд хэлэв: Нөхрийн маань зарц нар таныг “ариун Бурханы бошиглогч гэдгийг мөн түүний нэрээр олон гайхамшигт ажлуудыг хийх хүч танд байдгийг надад мэдүүллээ;

5 Тиймийн тул, хэрэв энэ нь нөхцөл аваас, би таныг нөхрийг минь очиж үзээсэй хэмээнэ, учир нь тэр орондоо хэвтүүлэгдээд хоёр өдөр мөн хоёр шөнө болж байна; мөн зарим нь түүнийг үхээгүй гэх юм, гэвч бусад зарим нь тэр үхчихсэн мөн тэр өмхийрч байна, мөн тэр хадан булшинд тавигдвал зохино гэх юм; гэвч миний хувьд, өөрт минь бол тэр өмхийрөөгүй.

6 Эдүгээ, Аммоны хүссэн нь энэ байв, учир нь Лемонай хаан Бурханы хүчний дор байгааг тэр мэдэж байв; итгэлгүй байдлын харанхуй “гивлүүр түүний оюунаас зайлуулагдаж, мөн түүний

оюуныг гэрэлтүүлсэн ⁶гэрэл, Бурханы алдар суугийн гэрэл болох тэр, мөн түүний сайн сайхны гайхамшигт гэрэл болох тэр—тийм ээ, харанхуйн үүлс ярагдсаны дараа энэ гэрэл түүний бодгальд маш их баяслыг төрүүлснийг мөн үүрдийн амьдралын гэрэл түүний бодгальд гэрэлтсэнийг тэр мэдэж байв, тийм ээ, энэ нь түүний буй биеийг хальж, мөн тэрээр оюун санааныхаа хувьд Бурханаар аваачигдсаныг тэрээр мэдсэн бөлгөө—

7 Тиймийн тул, хатны түүнээс хүссэн нь түүний цорын ганц хүсэл байв. Тиймийн тул, тэрээр өөрөөс нь хатны хүссэний дагуу хааныг үзэхээр оров; мөн тэрээр хааныг үзэж, мөн тэрээр түүнийг үхээгүйг мэдэв.

8 Мөн тэрээр хатанд хэлэв: Тэр үхээгүй, харин тэр Бурханы хувьд унтаж байна, мөн маргааш тэр дахин босох болно; тиймийн тул түүнийг бүү оршуул.

9 Мөн Аммон түүнд хэлэв: Та үүнд итгэв үү? Мөн тэр түүнд хэлэв: Таны үгнээс мөн зарц нарын маань үгнээс өөр гэрч надад үгүй байна; гэсэн хэдий ч би энэ нь таны хэлсний дагуу байх болно хэмээн итгэнэ.

10 Мөн Аммон түүнд хэлэв: Үлэмж итгэлийнхээ учир адислагдсан болой та; би танд

хэлнэ, эмэгтэй, бүх нифайчуудын хүмүүсийн дунд ч ийм агуу их “итгэл үгүй билээ.

11 Мөнхүү улиран тохиох дор тэрээр тэр цагаас Аммоны товловсон, түүний босох ёстой маргаашийн тэрхүү цагийг хүртэл нөхрийнхөө орон дээр сахив.

12 Мөнхүү улиран тохиох дор тэр Аммоны үгсийн дагуу босов; мөн тэр босохдоо, гараа сайхь эмэгтэйн зүг сунгаж, мөн хэлэв: Бурханы нэр алдаршиг, мөн адислагдсан болой та.

13 Учир нь таны амьд нь гарцаагүйн адил, болгоогтун, би өөрийн Гэтэлгэгчийг харав; мөн тэр ирнэ, мөн “эмэгтэйгээс ⁶төрөн, мөн өөрийнх нь нэрэнд итгэх бүх хүн төрөлхтнийг тэр гэтэлгэх болно. Эдүгээ, тэрээр энэ үгсийг хэлэхдээ, түүний дотор зүрх сэтгэл нь уужирч, мөн тэрээр баяслаасаа болоод дахин унав; мөн түүнчлэн хатан ч унаж, Сүнсээр давамгайлагдаж байсны учир болой.

14 Эдүгээ Аммон түүний ах дүүс болох нифайчуудын дунд, эсвээс Бурханы бүх хүмүүсийн дунд өөрсдийн алдсууд хийгээд “уламжлалуудын учир тийм их гашуудлын шалтгаан болсон леменчүүдийн дээр Их Эзэний Сүнс түүний ⁶залбирлуудын дагуу цутгагдаж буйг хараад, өвдөг дээрээ унаж,

6б су Гэрэл, Христийн гэрэл.
10а Лук 7:9.
су Итгэл.

13а 1 Ниф. 11:13–21.
б су Есүс Христ—
Есүс Христийн төрөлт болон нас

баралтын тухай бошиглал.
14а Мозая 1:5.
б С ба Г 42:14.

мөн түүний ах дүүсийн төлөө хийсэн зүйлийн төлөө Бурханд талархан мөн залбиралд сэтгэл оюунаа уудалж эхлэв; мөн тэрээр түүнчлэн “баясалдаа дийлдэн байв; мөн тийн тэд гурвуулаа газарт ‘унав.

15 Эдүгээ, хааны зарц нар тэдний унасныг хараад, тэд түүнчлэн Бурханд залбирч эхлэв, учир нь Их Эзэнээс эмээх айдас тэдэнд түүнчлэн ирсэн байв, учир нь хааны өмнө зогсож мөн түүнд Аммоны агуу их хүчний талаар гэрчилсэн “гэд байв.

16 Мөнхүү улиран тохиох дор бүр тэд бүгд, Лемен үндэсний Эбиш гэгч нэгэн бүсгүйгээс бусад нь, газарт унах хүртлээ Их Эзэний нэрийг өөрсдийн хүчээр дуудав, тэр бүсгүй эцгийнхээ гайхамшигт үзэгдлийн учир олон жилийн өмнө Их Эзэнд хөрвүүлэгдсэн аж—

17 Тийн Их Эзэнд хөрвүүлэгдсэн учир, мөн үүнийг хэзээ ч мэдүүлээгүйн учир, тиймийн тул, тэрээр Лемонайн бүх зарц нар газарт унасныг, мөн түүнчлэн эзэгтэй нь, хатан, мөн хаан, мөн Аммон газарт тэрийн хэвтэхийг хараад, энэ бол Бурханы хүч гэдгийг тэр бүсгүй мэдэв; мөн тэдний дунд тохиолдсоныг хүмүүст мэдүүлснээр, тэд энэ байдлыг болгоогоод энэ боломж нь тэднийг Бурханы хүчинд итгүүлнэ “хэмээн бодсон учир, тиймийн

тул сайхь бүсгүй байшингаас байшин хүртэл гүйж, үүнийг хүмүүст мэдүүлсээр байв.

18 Мөн тэд хааны гэрт өөрсдөө нэгдэн цугларч эхлэв. Мөн олон ард ирж, мөн тэд хааныг мөн хатныг, бас тэдний зарц нар газарт тэрийн хэвтэхийг гайхаж балмагдан харав, мөн тэд бүгд үхсэн мэтээр хэвтэж байв; мөн түүнчлэн тэд Аммоныг харав мөн болгоогтун тэр нь нифай үндэстэн хүн байв.

19 Мөн эдүгээ хүмүүс өөр хоорондоо бувтналдаж эхлэв; зарим нь нифай хүн уг нутагт “үлдэхийг тэрээр зөвшөөрсөн учир, тэдний дээр, эсвээс хааны мөн түүний гэрийн дээр агуу хилэнц нүүрлэж хэмээцгээв.

20 Гэвч бусад зарим нь тэднийг зэмлэж, хэлрүүн: Тэр “Себасын усны дэргэд сүргээ тараалгасан зарц нараа алсан учир, хаантан гэрийнхээ дээр энэ хилэнцийг авчирсан ажээ.

21 Мөн түүнчлэн тэд Себасын усанд босож мөн хаанд өмчлөгдсөн сүргийг “тараасан тэдгээр эрчүүдээр зэмлэгдэв, учир нь хааны сүргийг хамгаалж байхдаа Себасын усанд түүний алсан өөрсдийнх нь ах дүүсийн тооны учир тэд Аммонд уурлаж байв,

22 Эдүгээ, ах нь Аммоны илдэнд “алагдсан нэг нь, тэр Аммонд үлэмж уурласан учир

14в су Баяр баясгалан.
г Алма 27:17.
15а Алма 18:1–2.

17а Мозая 27:14.
19а Алма 17:22–23.
20а Алма 17:26; 18:7.

21а Алма 17:27; 18:3.
22а Алма 17:38.

илдээ сугалж мөн тэрээр үүнийг Аммоны дээр, түүнийг алахаар буулгаж болохын тулд урагшлав; мөн тэрээр түүнийг цохихоор илдээ өргөхөд, болгоогтун, тэр үхэхийн унав.

23 Эдүгээ Аммон алагдахгүйг бид харлаа, учир нь “Их Эзэн түүний эцэг Мозаяд ийн хэлсэн ажгуу: Би түүнийг хэлтрүүлэх болно, мөн энэ нь таны итгэлийн дагуу түүнд байх болно—тиймийн тул, Мозая Их Эзэнд түүнийг ^бдаатгасан байжээ.

24 Мөнхүү улиран тохиох дор ард олон Аммоныг алахаар илдээ далайсан мөнөөх эр үхэхийн унахыг болгоогоод, тэд бүгдийн дээр айдас хургаж мөн тэд түүнд эсвээс унасан буй тэдний хэнд нь ч хүрэхээр гараа хөдөлгөж зүрхэлсэнгүй; мөн тэд дахин өөр хоорондоо юу энэ агуу их хүчийг гаргаж чадахыг эсвээс энэ зүйлүүд ямар утгатай болохыг гайхаж эхлэв.

25 Мөнхүү улиран тохиох дор тэдний дунд Аммон бол “Агуу Их Сүнс байсан хэмээн хэлэх нь олон байв, мөн бусад зарим нь Агуу Их Сүнсээр илгээгдсэн хэмээв.

26 Гэвч бусад зарим нь тэднийг бүгдийг зэмлэж, тэр бол нифайчуудаас тэднийг тарчлаахаар илгээгдсэн мангас мөн хэмээв.

27 Мөн тэдний алдсуудын учир тэднийг зовоохоор

Аммон Агуу Их Сүнсээр илгээгдсэн хэмээн хэлсэн зарим нь байв; мөн нифайчуудыг үргэлж харж ханддаг, тэднийг өөрсдийг нь гараас ямагт чөлөөлдөг байсан нь Агуу Их Сүнс юм; мөн тэд өөрсдийнх нь ах дүүс болох леменчүүдээс тийм олныг устгасан тэрхуу Агуу Их Сүнс нь энэ байв.

28 Мөн тийн тэдний дундах зөрчилдөөн үлэмж хурц болж эхлэв. Мөн тэд ийн тэмцэлдэж байхад, ард олныг цугларахад хүргэсэн мөнөөх “эмэгтэй зарц ирж, ард олны дундах зөрчлийг хараад тэрээр үлэмж харамсан, бүр нулимс унагав.

29 Мөнхүү улиран тохиох дор тэр явж, тэрээр магад түүнийг газраас босгож болохын тулд хатныг гараас нь барив; мөн тэрээр түүнд гар хүрмэгц тэр босож мөн хөл дээрээ зогсов, мөн чанга дуугаар хашгирч хэлэв: Ай алдар нь бадарсан Есүс, намайг “аймшигт тамаас аварсан тэр! Ай алдар нь бадарсан Бурхан, энэ хүмүүсийн дээр ^бнигүүллийг соёрхооч!

30 Мөн тэр үүнийг хэлээд, тэр гараа хавсрав, учир нь тэр баяслаар дүүрсэн байж, мөн ойлгогдоогүй олон үгийг ярив; мөн тэрээр үүнийг хийгээд, тэр хаан Лемонайг гараас нь барихад, мөн болгоогтун тэр босож мөн хөл дээрээ зогсов.

23a Мозая 28:7;
Алма 17:35.
б су Итгэл.

25a Алма 18:2–5.
28a Алма 19:16.
29a 1 Ниф. 14:3.

б су Нигүүлсэнгүй,
Нигүүлсэл.

31 Мөн тэрээр, тэр даруй, өөрийн хүмүүсийн дундах зөрчлийг хараад, явж мөн тэднийг зэмлэж эхлэв, мөн Аммоны амнаас өөрийн дуулсан “үгсээ тэдэнд зааж эхлэв; мөн сонссон бүхэн түүний үгсэд итгэж, мөн Их Эзэнд хөрвүүлэгдэв.

32 Гэвч тэдний дунд түүний үгсийг сонсохгүй нь олон байв; тиймийн тул тэд өөрсдийн замаар одов.

33 Мөнхүү улиран тохиох дор Аммон босоод түүнчлэн тэдэнд туслав, мөн Лемонайн бүх зарц нар түүнчлэн үйлдэв; мөн тэд бүгд хүмүүст нэгэн адил зүйлийг — тэдний зүрх сэтгэл “өөрчлөгдсөнийг; тэд ^бхилэнцийг үйлдэх хүсэлгүй болсныг тунхаглав.

34 Мөн болгоогтун, олон нь тэд “тэнгэр элчүүдийг харсан мөн тэдэнтэй ярилцсан хэмээн хүмүүст тунхаглав; мөн тийн тэд Бурханы мөн түүний зөв шударгын зүйлүүдийг тэдэнд өгүүлэв.

35 Мөнхүү улиран тохиох дор тэдний үгсэд итгэсэн олон нь байв; мөн итгэсэн болгон “баптисм хүртэв; мөн тэд зөв шударга хүмүүс болж, мөн тэд дундаа сүм байгуулав.

36 Мөн тийн Их Эзэний ажил леменчүүдийн дунд үүссэн болой; тийн Их Эзэн өөрийн Сүнсийг тэдний дээр цутгаж эхлэв; мөн наманчилж мөн түүний нэрэнд итгэх “бүх

хүмүүст түүний мутар сунгаастай байдгийг бид харлаа.

БҮЛЭГ 20

Их Эзэн шоронд орсон ах дүүсийг нь чөлөөлүүлэхээр Миддонитийш Аммоныг илгээв — Аммон, Лемонай бүх нутгийн дээрх хаан болох Лемонайн эцэгтэй уулзав — Аммон ах дүүсээ суллуулахыг зөвшөөрүүлэхээр өвгөн хааныг албадав. Ойролцоогоор мээ 90 он.

Мөнхүү улиран тохиох дор тэд уг нутагт сүм байгуулаад, Лемонай хаан тэрээр түүнийг эцэгтээ үзүүлж болохын тулд Аммоныг түүнтэй хамт Нифайн нутаг тийш явахыг хүсэв.

2 Мөн Их Эзэний дуу хоолой Аммонд ирж, хэлрүүн: Чи Нифайн нутаг өөд явах ёсгүй, учир нь болгоогтун, хаан амийг чинь эрэлхийлэх болно; гэвч чи Миддонай нутаг тийш явах ёстой; учир нь болгоогтун, чиний ах Аарон, мөн түүнчлэн Мулокай мөн Амма нар шоронд байна.

3 Эдүгээ улиран тохиох дор Аммон үүнийг дуулаад, тэрээр Лемонайд хэлэв: Болгоогтун, ах минь мөн ах дүүс минь Миддонай дахь шоронд байна, мөн би тэднийг чөлөөлж болохын тулд би явна.

4 Эдүгээ Лемонай Аммонд хэлэв: Би мэднэ, Их Эзэний “хүчинд та бүх зүйлийг хийж

31a Алма 18:36–39.

33a су Дахин төрөх,
Бурханаас төрөх.
б Мозая 5:2;

Алма 13:12.

34a су Тэнгэр элчүүд.
35a су Баптисм,
Баптисм хүртээх.

36a 2 Ниф. 26:33;

Алма 5:33.
20 4a Алма 26:12.

чадна. Гэвч болгоогтун, би тантай Миддонай нутгийн зүг явах болно; учир нь Миддонай нутгийн хаан, Антиомно нэртэй нэгэн, надад найз минь билээ; тиймийн тул би Миддонай нутгийн зүг явна, би уг нутгийн хааныг зусардаж болохын тулд, мөн тэрээр таны ах дүүсийг “шоронгоос гаргах болно. Эдүгээ Лемонай түүнд хэлэв: Ах дүүсийг тань шоронд буйг танд хэн хэлэв?

5 Мөн Аммон түүнд хэлэв: Бурханаас өөр хэн ч надад хэлсэнгүй; мөн тэр надад — Яв мөн ах дүүсээ чөлөөл, учир нь тэд Миддонай нутаг дахь шоронд байна хэмээсэн хэллээ.

6 Эдүгээ Лемонай үүнийг дуулаад тэрээр зарц нараараа “морьд мөн сүйх тэргээ бэлэн болгуулав.

7 Мөн тэрээр Аммонд хэлсэн нь: Ирэгтүн, би тантай хамт Миддонай нутаг уруу явах болно, мөн таны ах дүүсийг шоронгоос гаргахыг хаанаас нь би гуйх болно.

8 Мөнхүү улиран тохиох дор Аммон, Лемонай нар тийш аялах зуураа, тэд бүх нутгийн “дээрх хаан болох Лемонайн эцэгтэй уулзав.

9 Мөн болгоогтун, Лемонайн эцэг түүнд хэлж: Би өөрийн хөвгүүд, мөн өөрийн хүмүүст зориулан хийсэн зоогийн их өдөр та нар яагаад “зоогонд ирсэнгүй вэ?

10 Мөн түүнчлэн тэр хэлэв:

“Худалчийн хүүхдүүдийн нэг болох энэ нифай үндэсний эртэй чи хаачихнав?

11 Мөнхүү улиран тохиох дор Лемонай хааш явж байгаагаа түүнд тоочин хэлэв, учир нь тэр түүнийг гомдоохоос эмээсэн ажээ.

12 Мөн түүнчлэн түүний бэлтгэсэн эцгийнхээ зоогонд очоогүйн шалтгаан, түүний өөрийнх нь хаант улсад түүнийг саатуулсан бүх учрыг тэрээр түүнд хэлэв.

13 Мөн эдүгээ Лемонай түүнд эдгээр бүх зүйлийг тоочиход, болгоогтун, түүний гайхлыг төрүүлж, эцэг нь түүнд уурлаж, мөн хэлэв: Лемонай чи худалчийн хөвгүүд болох эдгээр нифайчуудыг чөлөөлүүлөх гэж явна. Болгоогтун, тэр худалч чинь бидний эцэг өвгөдийг дээрэмдсэн; мөн эдүгээ түүний хүүхдүүд түүнчлэн тэд өөрсдийн башир арга мөн өөрсдийн худал хуурмагаараа тэд биднээс бидний хөрөнгийг дээрэмдэж болохын тулд биднийг мэхэлж болохын тулд бидний дунд иржээ.

14 Эдүгээ Лемонайн эцэг түүнд тэрээр Аммоныг илдээр алахыг зарлиглав. Мөн түүнчлэн тэрээр тэр Миддонай нутаг тийш явах ёсгүй, харин тэр өөртэй нь хамт “Ишмэилийн нутагт буцах ёстой хэмээн түүнд зарлиглав.

15 Гэвч Лемонай түүнд хэлэв: Би Аммоныг алахгүй бас Ишмэилийн нутагт ч

буцахгүй, харин би Аммоны ах дүүсийг суллуулж болохын тулд Миддонай нутаг тийш явна, учир нь тэд бол шударга эрчүүд мөн үнэн Бурханы ариун бошиглогчид гэдгийг би мэднэ.

16 Эдүгээ түүний эцэг эдгээр үгийг дуулаад, тэрээр түүнд уурлаж, мөн тэр түүнийг цохин газарт унагаж болохын тулд илдээ сугалав.

17 Гэвч Аммон урагш зогсож мөн түүнд хэлэв: Болгоогтун, та хүүгээ алах ёсгүй; гэсэн хэдий ч, танаас илүү “тэр унавал дээр, учир нь болгоогтун, тэр нүглүүдээ наманчилсан; харин хэрэв та энэ цагт, уур хилэндээ байхад унах юм бол, бодгаль тань аврагдаж чадахгүй.

18 Мөн үүнчлэн, та түдгэлзэх нь зүйд нийцнэ, учир нь хэрэв та хүүгээ “албал, тэр гэмгүй хүн байсны учир, түүний цус газраас Их Эзэн Бурхандаа хашгирч, өшөөг нь таны дээр ирүүлэхийн учир болой; мөн та сүнсээ ч алдаж болзошгүй.

19 Эдүгээ Аммон эдгээр үгийг түүнд хэлэхэд, тэр түүнд хариулж, хэлрүүн: Хэрэв би хүүгээ алах аваас би гэмгүй цусыг урсгах болно гэдгээ мэднэ; учир нь түүнийг устгахыг эрэлхийлсэн нь та болой.

20 Мөн тэрээр Аммоныг алахаар гараа сунгав. Гэвч Аммон түүний дайралтыг тогтоож мөн түүнчлэн тэр хэрэглэж

чадахгүй болгож гарыг нь цохив.

21 Эдүгээ Аммон өөрийг нь алж чадахыг хаан хараад, тэрээр амиа хэлтрүүлэхийг Аммоноос гуйж эхлэв.

22 Гэвч Аммон илдээ өргөж, мөн түүнд хэлэв: Болгоогтун, миний ах дүүс шоронгоос гаргагдах болно гэдгийг та зөвшөөрөхгүй бол би таныг цохих болно.

23 Эдүгээ хаан, тэрээр амиа алдах нь хэмээн айсан учир, хэлсэн нь: Хэрэв та намайг хэлтрүүлбэл би юу гуйсныг тань, бүр хаант улсынхаа хагасыг ч танд олгох болно гэв.

24 Эдүгээ Аммон өвгөн хаанд хүслийнхээ дагуу нөлөөлснөө хараад, тэрээр түүнд хэлсэн нь: Хэрэв та ах дүүс минь шоронгоос гаргагдаж болохыг, мөн түүнчлэн Лемонай өөрийн хаант улсыг хадгалж болохыг, мөн та түүнд үл дургүйцэж, харин тэр хүслийнхээ дагуу “юу бодсоноо хийж болохыг түүнд зөвшөөрвөл, тэгвэл би таныг хэлтрүүлэх болно; үгүй бол би таныг газарт нам дарах болно.

25 Эдүгээ Аммон эдгээр үгийг хэлэхэд, хаан амийнхаа тул баясаж эхлэв.

26 Мөн Аммон өөрийг нь устгах хүсэлгүй байгааг тэр хараад, мөн түүнчлэн тэр өөрийнх нь хүү Лемонайд их хайртайг хараад, тэр үлэмж гайхан балмагдаж, мөн хэлэв: Би таны ах дүүсийг чөлөөлж

мөн хүү Лемонайдаа хаант улсаа хадгалахыг зөвшөөрөх нь таны бүх хүсэл учир, болгоогтун, миний хүү хаант улсаа энэ цагаас мөн үүрд хадгалж болохыг би зөвшөөрч байна; мөн би түүнийг хойшид захирах нь үгүй —

27 Мөн түүнчлэн би таны ах дүүс шоронгоос гаргагдаж болохыг, мөн та болон ах дүүс тань над дээр миний хаант улсад ирж болохыг зөвшөөрө; учир нь би таныг харахыг маш ихээр хүсэх болно. Учир нь хаан түүний ярьсан мөн түүнчлэн өөрийн хүү Лемонайгаар яригдсан үгсэд ихээр гайхаж балмагдсан ажгуу, тиймийн тул тэрээр тэдгээрийг “мэдэх хүсэлтэй байв.

28 Мөнхүү улиран тохиох дор Аммон, Лемонай нар өөрсдийн Миддони нутгийн зүг аянаа үргэлжлүүлэв. Мөн Лемонай уг нутгийн хааны мэлмийд тааллыг олжээ; тиймийн тул Аммоны ах дүүс шоронгоос гаргагдаж авчрагдав.

29 Мөн Аммон тэдэнтэй уулзахдаа тэр үлэмж харамсав, учир нь болгоогтун тэд нүцгэн мөн бөх олсоор хүлэгдсэн учир арьс нь үлэмж гэмтсэн байв. Мөн тэд түүнчлэн өлсгөлөн, харангадалт, мөн бүхий л төрлийн зовлонгуудыг тэвчсэн байв; гэсэн хэдий ч тэд бүх зовлонгууддаа “тэвчээртэй байжээ.

30 Мөн тохиолдлоор, илүү хатуу мөн илүү зөрүүд хүмүү-

сийн гарт орсон нь тэдний хувь тавилан байжээ; тиймийн тул тэд тэдний үгийг дуулахгүй байсан аж, мөн тэд тэднийг хөөж, мөн тэднийг цохьсон аж, мөн тэднийг байшингаас байшинд, газраас газарт хүртэл, бүр тэд Миддони нутагт хүрч ирэх хүртэл хэсүүлсэн байв; мөн тэнд тэд баривчлагдаж, мөн шоронд хаягдаж, мөн “бөх олсоор хүлэгдэж, тэгээд олон хоногийн турш шоронд хоригдсон ажээ, мөн Лемонай, Аммон хоёроор чөлөөлөгдсөн болой.

Аарон, мөн Мулокай мөн тэдний ах дүүс леменчүүдэд номлосон тухай шастир оршвой.

21-ээс 26 дугаар бүлэгт агуулагдав.

БҮЛЭГ 21

Христ болон түүний цагаатгалын тухай Аарон амалекайчуудад заав—Аарон болон түүний ах дүүс Миддони дахь шоронд хоригдов—Тэд чөлөөлөгдсөний дараа, тэд синагогуудад зааж мөн олныг элсүүлэв—Лемонай Ишмил нутаг дахь хүмүүст шашны эрх чөлөөг зөвшөөрөв. Ойролцоогоор мээ 90–77 он.

Эдүгээ Аммон мөн түүний ах дүүс леменчүүдийн нутгийн хил дээр “салцгаахад, болгоогтун, Аарон леменчүүдээр эцэг өвгөдийнхөө унасан нутгийн

нэрээр Иерусалим гэж нэрлэгдсэн нутгийн зүг аянаа хөөв; мөн энэ нь Мормоны хилийн ойролцоо зайдуу оршиж байв.

2 Эдүгээ леменчүүд мөн амалекайчууд мөн "Амюлоны хүмүүс Иерусалим гэж нэрлэгдсэн их хотыг барьсан байв.

3 Эдүгээ леменчүүд өөрсдөө хангалттай хатуу, гэвч амалекайчууд мөн амюлончууд бүр илүү хатуу байв; тиймийн тул леменчүүдийг тэд зүрх сэтгэлээ хатууруулж, тэд ёс бусад мөн өөрсдийнх нь жигшүүрт хэргүүдэд тэд илүү хүчтэй болгож байв.

4 Мөнхүү улиран тохиох дор Аарон Иерусалим хотод ирж, мөн эхлээд амалекайчуудад номлож эхлэв. Мөн тэрээр өөрсдийнх нь синагогуудад тэдэнд номлож эхлэв, учир нь тэд нихоруудын жаягийн дагуу синагогуудыг барьсан байв; учир нь амалекайчууд мөн амюлончуудын олон нь нихоруудын "жаягийн дагуу байв.

5 Тиймийн тул, Аарон тэдний синагогуудын нэгэнд нь хүмүүст номлохоор ороход, мөн тэдэнд ярьж байхад, болгоогтун нэг амалекай үндэсний хүн босож мөн түүнтэй маргаж эхлэв, хэлрүүн: Таны гэрчилсэн чинь юу билээ? Та "тэнгэр элчийг харсан гэж үү? Тэнгэр элчүүд яагаад бидэнд үзэгддэггүй вэ?

Болгоогтун энэ хүмүүс таны хүмүүс шиг сайн биш хэрэг үү?

6 Түүнчлэн, бид наманчлахгүй аваас бид эрсдэх болно хэмээн та хэллээ. Та яаж бидний зүрхэн дэх бодол хийгээд зорилгыг мэдэв? Бидэнд наманчлах шалтгаан буйг та яаж мэдэв? Та яаж бид зөв шударга хүмүүс бус гэдгийг мэдэв? Болгоогтун, бид дуганууд барьж, мөн бид Бурханыг бишрэн сүсэглэхээр өөрсдөө цугларцгаадаг. Бурхан бүх хүмүүнийг аврах болно гэдэгт бид итгэдэг.

7 Эдүгээ Аарон түүнд хэлэв: Бурханы Хүү хүн төрөлхтнийг нүглүүдээс нь гэтэлгэхээр ирэх болно гэдэгт та итгэдэг үү?

8 Мөн нөгөөх хүн түүнд хэлэв: Бид таныг нэг ч ийм зүйл мэддэг гэдэгт итгэхгүй байна. Бид эдгээр мунхаг уламжлалд итгэхгүй байна. Ирэх "зүйлүүдийн тухай мэддэг, бас таны эцэг өвгөд мөн түүнчлэн бидний эцэг өвгөд өөрсдийнхөө ярьдаг байсан зүйлийн талаар, ирэх түүний талаар мэддэг байсан гэдэгт бид итгэдэггүй.

9 Эдүгээ Аарон тэдэнд Христийн ирэлтийн талаар, мөн түүнчлэн нас барагсдын амилуулалтын талаарх судруудыг, мөн Христийн зовлон хийгээд үхэл, мөн түүний цусны "цагаатгалаар бус аваас хүн төрөлхтний төлөө ⁶гэтэл-

2a Мозая 24:1;
Алма 25:4–9.
4a Алма 1:2–15.

5a Мозая 27:11–15.
8a Иаков 7:1–8.
9a су Цагаатгах,

Цагаатгал.
6 Мозая 5:8;
Алма 38:9.

гэл байж чадахгүй байсан тухай тэдэнд дэлгэж эхлэв.

10 Мөнхүү улиран тохиох дор тэр эдгээр зүйлийг тэдэнд тайлбарлаж эхлэхэд тэд түүнд уурлаж, мөн түүнийг дооглож эхлэв; мөн тэд түүний ярьсан үгсийг сонсохоос татгалзсан ажээ.

11 Тиймийн тул, тэрээр тэд түүний үгсийг сонсохоос татгалзсаныг хараад, тэр тэдний синагогоос гарч одов, мөн Анай-Антай гэж нэрлэгдсэн тосгонд ирж, мөн тэнд Мулокай тэдэнд номлож байхыг мөн түүнчлэн Амма мөн түүний ах дүүсийг тэр олов. Мөн тэд үгийн тухай олон хүмүүстэй маргалдав.

12 Мөнхүү улиран тохиох дор тэд зүрх сэтгэлээ хатууруулах хүмүүс гэдгийг харж, тиймийн тул тэд одож мөн Миддони нутагт хүрч ирэв. Мөн тэд үгийг олонд номлов, мөн тэдний заасан үгсэд итгэсэн нь цөөн байв.

13 Гэсэн хэдий ч, Аарон мөн хэдэн тооны түүний ах дүүс баривчлагдаж мөн шоронд хаягдав, мөн тэднээс үлдсэн нь Миддони нутгаас гарч эргэн тойрны газруудад зугтан гарав.

14 Мөн шоронд хаягдсан тэд олон зүйлийг “тэвчиж, мөн тэд Лемонай Аммон хоёрын гараар чөлөөлөгдөж, мөн тэднийг хооллож мөн хувцаслав.

15 Мөн тэд дахин үгийг тунхаглахаар явж мөн тийн тэд эхнийхээ удаа шоронгоос

чөлөөлөгдөв; мөн тийн тэд зовсон байв.

16 Мөн тэд “Их Эзэний Сүнсээр удирдагдсан зүг рүү хааш боловч явж, амалекайчуудын синагог бүрд, эсвээс тэд орох зөвшөөрлийг олж чадах леменчүүдийн цуглаан бүр дээр Бурханы үгийг номлов.

17 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн тэднийг адисалж эхлэв, үүний хэрээр тэд олныг үнэний мэдлэгт авчирсан бөлгөө; тийм ээ, тэд олонд өөрсдийнх нь нүглүүдийн, мөн эцэг өвгөдийнх нь зөв бус уламжлалуудын талаар “итгүүлжээ.

18 Мөнхүү улиран тохиох дор Аммон Лемонай хоёр Миддони нутгаас тэдний өвлөж авсан нутаг асан Ишмэилийн нутагт эргэж ирэв.

19 Мөн Лемонай хаан Аммон өөрт нь үйлчлэхийг, өөрөөр хэлбэл түүний зарц байхыг зөвшөөрөхгүй байлаа.

20 Харин тэрээр Ишмэилийн нутагт синагогууд баригдах болгов; мөн тэрээр энэ хүмүүсийг, өөрөөр хэлбэл түүний засаглалд байсан хүмүүсийг нэгдэн цугларцгаах болгов.

21 Мөн тэрээр тэдний тул баясаж, мөн тэрээр тэдэнд олон зүйлийг заав. Мөн түүнчлэн түүний захиргаандахь хүмүүс гэдгийг, мөн тэд чөлөөт хүмүүс байсныг, тэд түүний эцэг болох хааны дарлалаас чөлөөлөгдсөнийг тэдэнд тунхаглав; учир нь

түүний эцэг тэрээр Ишмэилийн нутагт мөн эргэн тойрных нь бүх нутагт байсан хүмүүсийн дээр түүнийг засаглаж болохыг зөвшөөрсөн байв.

22 Мөн түүнчлэн тэр тэдэнд Их Эзэн өөрсдийн Бурханыг хүслийнхээ дагуу ямар ч газар байсан, хэрэв энэ нь Лемонай хааны засаглалын доорх нутаг аваас чөлөөтэй шүтэн бишрэх “эрхийг эдэлж болохыг тунхаглав.

23 Мөн Аммон Лемонай хааны хүмүүст номлов; мөнхүү улиран тохиох дор тэрээр тэдэнд зөв шударгад хамаарах бүх зүйлүүдийн талаар заасан болой. Мөн тэр байдгаараа хичээнгүйлэн өдөр бүр тэдэнд ухуулж байв; мөн тэд түүний үгсэд анхааран хандаж, мөн тэд Бурханы зарлигуудыг дагахдаа мэриймтгий байв.

БҮЛЭГ 22

Бүтээлтийн, Адамын уналтын, мөн Христээр дамжин ирэх гэтэлгэлийн төлөвлөгөөний тухай Лемонайн эцэгт Аарон заав—Хаан мөн бүх гэрийнхэн нь хөрвүүлэгдэв—Нифайчууд хийгээд леменчүүдийн хоорондох нутгийн зааг тайлбарлагдав. Ойролцоогоор мээ 90–77он.

Эдүгээ, Аммон Лемонайн хүмүүст үргэлжлүүлэн тийн зааж байх зуур, Аарон болон түүний ах дүүсийн шастирт бид эргэж оръё; учир нь

тэрбээр Миддони нутгаас одсоныхоо дараа тэр Сүнсээр Нифайн нутаг тийш, бүр Ишмэилийн нутгаас “бусад бүх нутгийн дээрх тэр хааны голомт уруу “удирдагдсан буюу; мөн тэр нь Лемонайн эцэг байв.

2 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хааны ордонд ах дүүсийнхээ хамт түүнд очиж, мөн хааны өмнө бөхийн, мөн түүнд хэлэв: Болгоогтун, Ай хаантан, бид Аммоны ах дүүс, шоронгоос таны “чөлөөлсөн тэд билээ.

3 Мөн эдүгээ, Ай хаантан, хэрэв та бидний амийг хэлтрүүлж хайрлавал бид таны зарц нар болно. Мөн хаан тэдэнд хэлсэн нь: Босогтун, учир нь би та нарт амийг чинь хэлтрүүлэх болно, мөн би та нарыг өөрийн зарц нар байхыг зөвшөөрөхгүй; харин би надад сургахыг та нараас шаардана; учир нь та нарын ах Аммоны үгсийн өгөөмөр мөн агуугийн учир сэтгэл оюундаа зарим талаар би түгшиж байна; мөн тэр яагаад та нартай Миддонигаас ирээгүйн шалтгааныг би мэдэхийг хүсч байна.

4 Мөн Аарон хаанд хэлэв: Болгоогтун, Их Эзэний Сүнс түүнийг өөр зүгт дуудсан; тэрээр Ишмэилийн нутаг тийш Лемонайн хүмүүст заахаар явсан билээ.

5 Эдүгээ хаан тэдэнд хэлэв: Их Эзэний Сүнсний талаар та нарын хэлсэн тань юу

билээ? Болгоогтун энэ бол намайг түгшээх тэр зүйл болой.

6 Мөн түүнчлэн, Аммон хэлсэн нь—“Хэрэв та нар наманчилбал аврагдах болно, мөн хэрэв та нар наманчлахгүй бол, та нар эцсийн өдөр зайлуулагдах болно гэсэн нь юу вэ?”

7 Мөн Аарон түүнд хариулж мөн түүнд хэлэв: Бурхан байдагт та итгэдэг үү? Мөн хаан хэлэв: Амалекайчууд Бурхан байдаг хэмээн хэлдгийг би мэднэ, мөн тэд түүнийг шүтэн бишрэхээр өөрсдөө цугларцгааж болохын тулд тэд дуганууд барихыг би тэдэнд зөвшөөрсөн бөлгөө. Мөн хэрэв эдүгээ та Бурхан байдаг гэж хэлбэл, болгоогтун би “итгэх болно.

8 Мөн эдүгээ Аарон үүнийг дуулж, зүрх нь баясаж эхлэв, мөн тэр хэлсэн нь: Болгоогтун, та амьд буй нь гарцаагүйн адил, Ай хаантан, Бурхан байдаг.

9 Мөн хаан хэлэв: Бурхан гэж бидний эцэг өвгөдийг Иерусалим нутгаас авчирсан тэр “Агуу Их Сүнс мөн үү?”

10 Мөн Аарон түүнд хэлэв: Тийм ээ, тэр бол Агуу Их Сүнс, бас тэрээр тэнгэр ба газар аль алинд нь буй бүх зүйлийг “бүтээсэн юм. Та үүнд итгэдэг үү?”

11 Мөн тэр хэлэв: Тийм ээ, Агуу Их Сүнс бүх зүйлийг бүтээсэн гэдэгт би итгэдэг, мөн та нарыг надад эдгээр бүх зүйлийн талаар хэлж өгөхийг би хүсч байна, мөн би таны үгсэд “итгэх болно.

12 Мөнхүү улиран тохиох дор хаан түүний үгсэд итгэхийг Аарон үзээд, тэрээр Адамын бүтээлтээс эхэлж, судруудыг—Бурхан хэрхэн хүнийг өөрийн дүр төрхөөр бүтээсэн хийгээд Бурхан түүнд зарлигууд өгснийг, мөн зөрчлийн учир хүмүүн унасныг хаанд “уншиж өгөв.

13 Мөн Аарон судруудыг Адамын “бүтээлтээс эхлэн түүнд тайлбарлаж, хүмүүний уналтыг, мөн тэдний эгэл байдал хийгээд түүнчлэн дэлхийн “үүслээс бэлтгэгдсэн, түүний нэрэнд итгэсэн хэнд боловч бүгдийн төлөө байдаг, Христээр дамжин ирэх гэтэлгэлийн “төлөвлөгөөг түүний өмнө дэлгэсэн болой.

14 Мөн хүн нэгэнт “унаснаас хойш тэрээр өөрөөсөө болоод юуг ч “хүртэх нь зохистой байж чадахгүй; гэвч Христийн зовлонгууд хийгээд үхэл нь тэдний нүглийг итгэл болон наманчлал зэргээр дамжуулан “цагаатгадаг; мөн тэрээр үхлийн хүлээсийг тасчиж, ингэснээр “булш ялалт үгүй болж, мөн үхлийн шаналал

6a Алма 20:17–18.

7a С ба Г 46:13–14.

9a Алма 18:18–28.

10a су Бүтээх, Бүтээл.

11a су Итгэлтэй байх,

Итгэл.

12a 1 Ниф. 5:10–18;

Алма 37:9.

13a Эхл. 1:26–28.

б 2 Ниф. 9:18.

в су Гэтэлгэлийн төлөвлөгөө.

14a су Адам Ева хоёрын

Уналт.

б 2 Ниф. 25:23;

Алма 42:10–25.

в Алма 34:8–16.

су Цагаатгах, Цагаатгал.

г Иса. 25:8;

1 Кор. 15:55.

нь сүр жавхланд найдах найд-
вараар уужруулагдсан билээ;
мөн Аарон эдгээр бүх зүй-
лийг хаанд тайлбарласан аж.

15 Мөнхүү улиран тохиох
дор Аарон эдгээр зүйлийг
түүнд тайлбарласны дараа,
хаан хэлэв: Таны ярьсан тэр-
хүү мөнх амьдралыг авч боло-
хын тулд би “юу хийх билээ?
Тийм ээ, энэ ёс бусын сүнсийг
цээжнээсээ үндсээр нь суга-
луулан, мөн Бурханаар ^бтөрж
болохын тулд, мөн түүний
Сүнсийг хүлээн авч, баяслаар
дүүргэгдэж болохын тулд, эц-
сийн өдөр би зайлуулагдах-
гүй байж болохын тулд би
юу хийх билээ? Болгоогтун,
тэр хэлэв, би энэхүү агуу
баяслыг хүлээн авч болохын
тулд би өөрийн эзэмшдэг
^ббүгдийг өгөх болно, тийм ээ,
би хаант улсаа орхих болно.

16 Гэвч Аарон түүнд хэлэв:
Хэрэв та энэ зүйлийг “хүсвэл,
хэрэв та Бурханы өмнө доош
бөхийх юм бол, тийм ээ, хэрэв
та бүх нүглүүдээ наманчил-
бал, мөн Бурханы өмнө доош
бөхийвөл, та хүлээн авах
болно гэдэгтээ найдсаар, мөн
итгэлтэйгээр түүний нэрийг
дуудвал, тэгвэл та хүссэн
тэрхүү ^бнайдварыг хүлээн
авах болно.

17 Мөнхүү улиран тохиох дор
Аарон эдгээр үгсийг хэлэхэд,
хаан Их Эзэний өмнө доош
“бөхийн өвдөг дээрээ сөхрөв;
тийм ээ, бүр тэрээр газар

дээр сунан хэвтэж, мөн хүч-
тэйгээр ^бхашгирч, хэлсэн нь:

18 Ай Бурхан, Бурхан бай-
даг хэмээн Аарон надад хэ-
лэв; мөн хэрэв Бурхан байдаг
бол, мөн хэрэв та Бурхан бол,
та өөрийгөө надад мэдүүлнэ
үү, мөн би таныг мэдэхийн
тулд мөн би нас барагсдаас
босгогдож, мөн эцсийн өдөр
аврагдаж болохын тулд би
бүх нүглүүдээ орхих болно.
Мөн эдүгээ хаан эдгээр үгийг
хэлээд, тэр үхсэн мэт цочир-
дон унав.

19 Мөнхүү улиран тохиох дор
зарц нар нь гүйлдэж мөн
хаанд тохиолдсон бүгдийг
хатанд хэлэв. Мөн тэр хаан
дээр ирэв; мөн тэр түүнийг
үхсэн мэт хэвтэж буйг, мөн
түүнчлэн Аарон болон түү-
ний ах дүүс түүний унагаагд-
саны шалтгаан мэт зогсохыг
хараад, тэр тэдэнд уурлаж,
мөн тэднийг баривчилж мөн
тэднийг алахыг зарц нартаа,
эсвээс хааны зарц нарт зар-
лиглав.

20 Эдүгээ зарц нар хааны
унасан шалтгааныг харсан
байв, тиймийн тул тэд Аарон
болон түүний ах дүүст гар
хүрч зүрхэлсэнгүй; мөн тэд
хатныг гуйж хэлсэн нь: Бол-
гоогтун, та яагаад тэдний нэг
нь л бид бүгдээс “илүү хүчтэй
байхад бид энэ хүмүүсийг
алахыг бидэнд зарлиглав?
Тиймийн тул бид тэдний
өмнө унах болно.

15a Үйлс 2:37.
б Алма 5:14, 49.
в Мат. 13:44–46;
19:16–22.

16a су Хөрвүүлэг,
Хөрвөгч.
б Ифер 12:4.
17a С ба Г 5:24.

б су Залбирал.
20a Алма 18:1–3.

21 Эдүгээ хатан зарц нарын айдсыг хараад түүнчлэн өөр дээр нь ямар нэгэн хилэнц ирэх буюу хэмээн өөрөө ч үлэмж айж эхлэв. Мөн зарц нартаа явж мөн хүмүүсийг дуудахыг тэр тэдэнд зарлиглав, Аарон болон түүний ах дүүсийг тэд алж болохын тулд болой.

22 Эдүгээ Аарон хатны шийдэмгий байдлыг хараад, тэрээр, түүнчлэн хүмүүсийн зүрх сэтгэлийн хатууг мэдэхийн учир, ард олон нэгдэн чуулах буюу хэмээн, мөн тэдний дунд агуу тэмцэл мөн зөрчил байх вий хэмээн айв; тиймийн тул тэрээр гараа сунган хааныг газраас босгож, мөн түүнд хэлэв: Бос. Мөн тэрээр хүчээ олж, хөл дээрээ зогсов.

23 Эдүгээ энэ нь хатан болон зарц нарын олон нь байхад хийгдсэн бөлгөө. Мөн тэд үүнийг хараад ихээр гайхаж, мөн айж эхлэв. Мөн хаан урагш алхаж, мөн тэдэнд тохинуулж эхлэв. Мөн тэрээр тэдэнд “тохинуулж, үүний хэрээр бүх гэрийнхэн нь Их Эзэнд ^бхөрвүүлэгдэв.

24 Эдүгээ хатны зарлигийн учир ард олон нэгдэн цугларч, мөн Аарон болон түүний ах дүүсийн учир тэдний дунд маш их бувтналдаан байж эхлэв.

25 Гэвч хаан тэдний дунд алхан орж мөн тэдэнд тохи-

нуулав. Мөн тэд Аарон болон түүнтэй хамт байсан тэдний тухайд тайтгаруулагдав.

26 Мөнхүү улиран тохиох дор хаан хүмүүсийн тайвширсныг хараад, тэрээр Аарон болон түүний ах дүүсийг ард олны дунд зогсоод, мөн тэд уг үгийг тэдэнд номлох болгов.

27 Мөнхүү улиран тохиох дор хаан бүх нутаг даяар, мөн Мантайн хилийг даган, дорноос өрнөдөд урсах Сидон голын эхийн дэргэд, Зарахемла нутгийн умардад байх аглаг буйдын хилд, дорнын тэнгисээс бүр өрнийн тэнгис хүртэл үргэлжилдэг, мөн тэнгисийн эргийн эргэн тойрон дахь тэрхүү аглаг буйдын нарийн хэсгээр “Зарахемла нутгаас тусгаарлагддаг байсан дорнодод мөн өрнөдөд, бүр тэнгистэй хиллэсэн эргэн тойрны бүх нутгуудад, өөрийн бүх нутагт байсан өөрийн бүх хүмүүсийн дунд ^бтунхаг илгээв—мөн тийн леменчүүд болон нифайчууд хуваагддаг байжээ.

28 Эдүгээ, леменчүүдийн илүү “залхаг хэсэг нь аглаг буйдад амьдарч, мөн майханд оршдог байв; мөн тэд Нифайн нутагт, өрнөдийн аглаг буйд даяар тархсан байв; тийм ээ, мөн түүнчлэн Зарахемла нутгийн өрнөдөд, тэнгисийн эргээр хиллэн, мөн Нифайн нутаг дахь өрнөдөд, өөрсдийн эцэг өвгөдийнхөө

23a су Тохинуулагч;
Номлох; Заах, Багш.
б су Хөрвүүлэг,

Хөрвөгч.
27a Омнай 1:13–17.
б Алма 23:1–4.

28a 2 Ниф. 5:22–25.

анхны өвийн газар, мөн тийн тэнгисийн эргийн дагуу хиллэж байв.

29 Мөн түүнчлэн нифайчууд тэднийг тийш түрсэн тэнд олон леменчүүд дорнын тэнгисийн эргээр байв. Мөн тийн нифайчууд бараг л леменчүүдээр хүрээлүүлсэн байлаа; гэсэн хэдий ч Нифайчууд аглаг буйдтай хиллэх умардын, Сидон голын эхэнд, дорноос өрнийг хүртэл, аглаг буйдаар хүрээлүүлэх бүх нутгийг эзэмшин авсан байв; умардад, тэд өөрсдийн “Өгөөмөр гэж нэрлэсэн бүр тэр нутгийг хүртэл ирсэн буюу.

30 Мөнхүү тэр нь “Эзгүйрэл гэж тэдний нэрлэсэн тэр нутагтай хиллэдэг байв, учир нь умардад маш хол орших энэ нь хүмүүсээр эзэмшигдээд мөн устгагдсан тэр нутагт хүрэх, энэ нь тэдний “анх буусан газар байсан тул Зарахемлагийн хүмүүсээр олж нээгдсэн газар, тэдний “ясных нь тухай бидний ярьсан тэр газар болой.

31 Мөн тэндээс өгсөн тэд өмнөд аглаг буйдад ирсэн ажээ. Тийн умард зүгийн нутаг “Эзгүйрэл хэмээн нэрлэгдэж, мөн өмнө зүгийн нутаг нь Өгөөмөр хэмээн нэрлэгдсэн ажгуу, төрөл бүрийн зэрлэг амьтдын зүйл бүрээр дүүргэгдсэн аглаг буйд байв, мөн зарим нь умард нутгаас хоол хайж ирсэн ажээ.

32 Мөн эдүгээ, Өгөөмөр

Эзгүйрэлтэй залгах хилээр, өрнөөс дорнын тэнгисийг хүртэл нифай үндэстэн хүний хувьд зөвхөн бүтэн хагас өдөр аялах “зай байв; мөн тийн Нифайн нутаг мөн Зарахемла нутаг бараг л усаар хүрээлэгдэж, өмнөд хэсгийн нутаг мөн умард хэсгийн нутгийн хооронд жижиг “хүзүүвч газар байв.

33 Мөнхүү улиран тохиох дор нифайчууд Өгөөмөр нутгийг эзэмшсэн байв, бүр өрнөөс дорнын тэнгисийг хүртэл, мөн тийн нифайчууд өөрсдийн мэргэн ухаанд, харуулууд мөн их цэргээр, леменчүүдийг өмнөдөд шахсан байлаа, тиймээс тэд нь умардад хойшид эзэмшилтэй байхгүйн тулд, тэд умард хэсгийн нутгийг тархан эзэмшихгүйн тулд болой.

34 Тиймийн тул леменчүүд зөвхөн Нифайн нутаг мөн эргэн тойрных нь аглаг буйдаас өөрийг эзэмшдэггүй байв, мөн эргэн тойронд нь аглаг буйд байлаа. Эдүгээ энэ нь нифайчуудын мэргэн ухаан — леменчүүд тэдний дайсан байсан учир өөрсдийг нь тал бүрээр зовоосныг тэд хүлцэхгүй байх сан, мөн түүнчлэн тэд өөрсдийн хүслүүдийн дагуу тийш зугтаж болох нутагтай байж болохын тулд болой.

35 Мөн эдүгээ би, үүнийг хэлснийхээ дараа, Аммон болоод Аарон, Омнер болон

29a Алма 52:9; 63:5.

30a Алма 50:34;
Морм. 4:1–3.

б Хил. 6:10.

в Мозая 8:7–12;
28:11–19.

31a Хил. 3:5–6.

32a Хил. 4:7.
б Алма 50:34.

Химнай, мөн тэдний ах дүүсийн шастирт дахин эргэж оръё.

БҮЛЭГ 23

Шашны эрх чөлөө тунхаглагдав — Долоон нутаг мөн хотод леменчүүд хөрвүүлэгдэв—Тэд өөрсдийгөө Антай-Нифай-Лихайчууд хэмээн нэрлэж мөн зүхлээс чөлөөлөгдөв—Амалекайчууд мөн амюлончууд үнэнийг эсэргүүцэв. Ойролцоогоор мээ 90–77 он.

Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор леменчүүдийн хаан өөрийн бүх хүмүүсийн дунд “тунхаг илгээж, тэдний нутгийн аль ч хэсэгт, тэд ямар ч газар байсан тэд Аммон, эсвээс Аарон, эсвээс Омнер, эсвээс Химнай, мөн Бурханы үгийг номлож яваа тэдний ах дүүсийн хэнд ч гар хүрэх ёсгүй хэмээв.

2 Тийм ээ, тэднийг хүлэхээр, эсвээс тэднийг шоронд хорихоор тэд гараа хүргэх ёсгүй; бас тэд тэдэн дээр нулимж, бас тэднийг цохиж, бас тэднийг синагогуудаасаа хөөж, мөн тэднийг шилбүүрдэх ёсгүй; бас тэд тэдний зүг чулуу шидэх ёсгүй, харин тэд тэдний байшингуудад мөн түүнчлэн тэдний ариун сүмүүд, мөн дугануудад чөлөөтэй нэвтрэх боломжтой хэмээх тогтоолыг тэрээр тэдний дунд илгээсэн бөлгөө.

3 Мөн тийн тэд хүссэнийхээ

дагуу явж мөн үгийг номлож болно, учир нь хаан, мөн бүх гэрийнхэн нь Их Эзэнд хөрвүүлэгдсэн байв; тиймийн тул тэрээр өөрийн тунхаглалыг өөрийн хүмүүст уг нутаг даяар, Бурханы үг ямар ч саадгүй байж болохын тулд, харин энэ нь бүх нутаг даяар түгэж, түүний хүмүүс эцэг өвгөдийнхөө ёс бус “уламжлалуудын талаар ойлгож болохын тулд, мөн тэд бүгд ах дүүс учир, мөн тэд алах, бас тонох, бас хулгайлах, бас садар самууныг үйлдэх, бас ямар ч төрлийн ёс бусыг үйлдэх ёсгүйг ойлгож болохын тулд тунхаглал илгээсэн буюу.

4 Мөн эдүгээ улиран тохиох дор хаан энэ тунхаглалыг илгээхэд, Аарон болон түүний ах дүүс хотоос хотод, мөн шүтлэгийн нэг өргөөнөөс нөгөөд явж, сүмүүд байгуулан, мөн леменчүүдийн дунд уг нутаг даяар, тэдний дунд Бурханы үгийг номлуулж мөн заалгахаар санваартнууд хийгээд багш нарыг томилж байв; мөн тийн тэд агуу амжилттай байж эхлэв.

5 Мөн мянга мянга нь Их Эзэний мэдлэгт авчрагдав, тийм ээ, мянга мянга нь Нифайчуудын “уламжлалд итгэх итгэлд авчрагдсан бөлгөө; мөн тэд одоо цагийг хүртэл доош гардуулагдаж ирсэн тэрхүү ⁶цэдгүүд хийгээд бошиглолуудад сургагдав.

6 Мөн итгэсэн болгон нь,

өөрөөр хэлбэл Аммон болон түүний ах дүүсийн номлоор, илчлэлт хийгээд бошиглолын суу билгийн, мөн тэднээр дамжуулан гайхамшгуудыг үйлдэх Бурханы хүчний дагуу үнэний мэдлэгт авчрагдсан болгон нь — тийм ээ, би та нарт хэлнэ, Их Эзэн амьдын адил, тэдний номлолд итгэн мөн Их Эзэнд “хөрвүүлэгдсэн леменчүүд болгон, Их Эзэн амьд нь гарцаагүйн адил ^бхэзээ ч итгэл алдраагүй нь гарцаагүй.

7 Учир нь тэд зөв шударга хүмүүс болсон билээ; тэд Бурханы эсрэг бас ах дүүсийнхээ хэнийх нь ч эсрэг дахин тулалдахгүйн тулд тэд эсэргүүцлийн зэр зэвсгээ доош тавьсан билээ.

8 Эдүгээ, Их Эзэнд хөрвүүлэгдсэн нь “тэд юм:

9 Ишмэил нутагт байсан леменчүүдийн хүмүүс;

10 Мөн түүнчлэн Миддони нутагт байсан леменчүүдийн хүмүүсээс;

11 Мөн түүнчлэн Нифайн хотод байсан леменчүүдийн хүмүүсээс;

12 Мөн түүнчлэн “Шиломын нутагт байсан, Шимлоны нутагт байсан, мөн Лемүелийн хотод, мөн Шимнеломын хот дахь тэр леменчүүдийн хүмүүсээс болой.

13 Мөн тэд бол Их Эзэнд “хөрвүүлэгдсэн леменчүүдийн хотуудын нэрс болой; мөн

тэд эсэргүүцлийн зэр зэвсгээ, тийм ээ, бүх дайны зэр зэвсгээ доош тавьсан тэд, ажээ; мөн тэд бүгдээрээ леменчүүд байв.

14 Мөн амалекайчууд нэгээс бусад нь, бас “амюлончуудаас нэг нь ч ^бхөрвүүлэгдсэнгүй; харин тэд, өөрсдийн оршдог нутгийн энэ хэсэгт хаа боловч, тийм ээ, мөн тэдний бүх тосгод мөн тэдний бүх хотуудад өөрсдийн зүрх сэтгэлийг, мөн түүнчлэн леменчүүдийн зүрх сэтгэлийг хатууруулсан ажээ.

15 Тиймийн тул, тэд наманчилж мөн үнэний мэдлэгт ирж, мөн хөрвүүлэгдсэн леменчүүдийн бүх хотыг бид дурдав.

16 Мөн эдүгээ улиран тохиох дор хаан мөн хөрвүүлэгдсэн тэд түүгээр ах дүүсээсээ ялгагдаж болохын тулд нэртэй байх хүсэлтэй байв; тиймийн тул хаан Ааронтай болон тэдний санваартнуудын олонтой нь, тэд ялгагдаж болохын тулд тэд өөрсдийн дээр авах ёстой нэрийн талаар зөвлөлдөв.

17 Мөнхүү улиран тохиох дор тэд өөрсдийн нэрсийг “Антай-Нифай-Лихайчууд хэмээв; мөн тэд энэ нэрээр нэрлэгдэж мөн цаашид леменчүүд гэж нэрлэгдсэнгүй.

18 Мөн тэд маш их ажилсаг хүмүүс болж эхлэв; тийм ээ, мөн тэд нифайчуудтай

6a су Хөрвүүлэг,
Хөрвөгч.
б Алма 27:27.
8a Алма 26:3, 31.

12a Мозая 22:8, 11.
13a Алма 53:10.
14a Алма 24:29.
б Мозая 23:31–39.

17a су Антай-Нифай-
Лихайчууд.

нөхөрсөг байв; тиймийн тул, тэд тэдэнтэй харилцааг нээж, мөн Бурханы “зүхэл тэднийг цаашид дагасангүй.

БҮЛЭГ 24

Леменчүүд Бурханы хүмүүсийн эсрэг ирэв—Антай-Нифай-Лихайчууд Христэд баясаж мөн тэнгэр элчүүдээр айлчлагдав—Тэд амиа хамгаалахаас илүүгээр үхлийг хүлцэхээр сонгов—Өөр олон леменчүүд хөрвүүлэгдэв. Ойролцоогоор мээ 90–77он.

Мөнхүү улиран тохиох дор Амюлоны нутагт байсан мөн Хилом нутаг дахь, мөн “Иерусалим нутагт байсан, эцэст нь, эргэн тойрны бүх нутаг дахь, өөрсөд дээрээ ⁶Антай-Нифай-Лихай нэрийг аваагүй мөн хөрвүүлэгдээгүй амалекайчууд мөн амюлончууд мөн леменчүүд, амалекайчуудаар мөн амюлончуудаар ах дүүсийнхээ эсрэг уур хилэнд өдөөн хатгагдав.

2 Мөн тэдний занал тэдний эсрэг үлэмж хүчтэй болж, бүр үүний хэрээр тэд хааныхаа өөдөөс эсэргүүцэж эхлэв, үүний хэрээр тэд түүнийг өөрсдийн хаан байлгахыг хүсэхгүй байв; тиймийн тул, тэд Антай-Нифай-Лихайн хүмүүсийн эсрэг зэвсэглэв.

3 Эдүгээ хаан хүүгийнхээ дээр хаант улсыг шилжүүлж, мөн тэрээр хүүгийнхээ нэ-

рийг Антай-Нифай-Лихай хэмээн нэрлэв.

4 Мөн леменчүүд Бурханы хүмүүсийн эсрэг дайнд бэлтгэл хийж эхэлсэн мөнхүү жил хаан хальж одов.

5 Эдүгээ Аммон болон түүний ах дүүс мөн түүнтэй хамт ирсэн тэд бүгд өөрсдийнх нь ах дүүсийг устгах гэсэн леменчүүдийн бэлтгэлийг үзээд, тэд Мидиан нутагт ирж, мөн тэнд Аммон бүх ах дүүстэйгээ уулзав; мөн тэндээсээ тэд Лемонай болон түүнчлэн түүний дүү Антай-Нифай-Лихайтай тэд леменчүүдээс өөрсдийгөө хамгаалахад юу хийвэл зохих талаар “зөвлөлдөөн хийж болохын тулд Ишмэилийн нутагт ирсэн ажгуу.

6 Эдүгээ Их Эзэнд хөрвүүлэгдсэн бүх хүмүүсийн дунд ах дүүсийнхээ эсрэг зэвсэг барих нэг ч бодгаль байсангүй; үгүй, тэд дайнд бүр ямар ч бэлтгэл хийхгүй байв; тийм ээ, мөн түүнчлэн хаан нь тэд тэгэх ёсгүйг тэдэнд зарлиглав.

7 Эдүгээ, эдгээр нь уг хэргийн талаар хүмүүст хэлсэн түүний үгс болой: Би Бурхандаа талархана, хайрт хүмүүс минь, бидний агуу их Бурхан сайн сайхны төлөө эдгээр ах дүүсийг маань, нифайчуудыг, бидэнд номлуулж, мөн ёс бус эцэг өвгөдийн маань “уламжлалуудыг

18a 1 Ниф. 2:23;
2 Ниф. 30:5–6;
3 Ниф. 2:14–16.

24 1a Алма 21:1.
б Алма 25:1, 13.
5a Алма 27:4–13.

7a Мозая 1:5.

бидэнд ойлгуулахаар бидэнд илгээсний учир болой.

8 Мөн болгоогтун, тэрээр бид эдгээр ах дүүс, нифайчуудтай харилцааг нээхийн тулд, бидний зүрхийг зөөллөхөөр бидэнд өөрийн Сүнсний хэсгийг өгсөнд нь би агуу их Бурхандаа талархана.

9 Мөн болгоогтун, энэ харилцааг нээснээр бид “нүглүүдээ, мөн өөрсдийн үйлдсэн олон аллагыг ойлгосондоо би түүнчлэн Бурхандаа талархана.

10 Мөн түүнчлэн би Бурхандаа талархана, тийм ээ, агуу их Бурхандаа, тэрээр эдгээр зүйлийг наманчилж болохыг бидэнд зөвшөөрсөнд нь, мөн түүнчлэн тэрээр бидний үйлдсэн олон нүглийг мөн аллагуудыг маань “өршөөсөнд нь мөн өөрийн Хүүгийн сайн үйлээр, бидний зүрх сэтгэлээс ⁶гэмийг зайлуулан авсанд нь талархана.

11 Мөн эдүгээ болгоогтун, ах дүүс минь, бидний хийж чадах бүхэн нь (бид бүх хүн төрөлхтнөөс хамгийн төөрөлдсөн нь байсан учир) өөрсдийн бүх нүглийг мөн үйлдсэн бүх аллагуудаа наманчилж, мөн Бурханаар тэдгээрийг зүрх сэтгэлээсээ зайлуулан “авахуулах учраас, тодруулбал бидний хийж чадах бүхэн нь Бурханы өмнө тэрээр бидний толбыг зайлуулахуйц хангалттайгаар наманчлах явдал юм —

12 Эдүгээ, хамгийн хайрт ах дүүс минь, Бурхан бидний толбуудыг зайлуулан авч, мөн илднүүд маань өнгөлөг болсон учир, тиймээс ах дүүсийнхээ цусаар илднүүдээ хойшид толботуулахгүй байцгаая.

13 Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй, илднүүдээ ах дүүсийнхээ цусанд толботуулалгүй хадгалцгаая; учир нь магадгүй, хэрэв бид илдээ дахин толботуулах аваас тэдгээр нь агуу их Бурханы маань Хүүгийн бидний нүглүүдийн цагаатгалын улмаас урсах цусаар дахин өнгөлөгдөн “угаагдах боломжгүй байх болно.

14 Мөн агуу их Бурхан бидний дээр нигүүлсэнгүй байж, мөн бид мөхөхгүйн тулд эдгээр зүйлийг бидэнд мэдүүлсэн билээ; тийм ээ, мөн тэрээр эдгээр зүйлийг урьдчилан бидэнд мэдүүлсэн юм, яагаад гэвэл тэрээр хүүхдүүдэд маань хайртайн адил бидний “бодгальд ч бас хайртай; тиймийн тул, ирээдүйн үеүдийн адил бидэнд ч ⁶авралын төлөвлөгөө мэдүүлэгдэж болохын тулд өөрийн нигүүлсэлд тэрээр тэнгэр элчүүдээрээ бидэнд айлчилдаг.

15 Ай, бидний Бурхан хичнээн нигүүлсэнгүй билээ! Мөн эдүгээ болгоогтун, бид өөрсдөөсөө толбуудыг зайлуулан авахуулах нь бидний хийж чадах бүх зүйл байлаа,

9а С ба Г 18:44.

10а Дан. 9:9.

б су Гэм.

11а Иса. 53:4–6.

13а Илч. 1:5.

14а су Хүн—Хүний үнэ

цэнэ.

б су Гэтэлгэлийн

төлөвлөгөө.

мөн бидний илд өнгөлөг болгогдсон учир, эцсийн өдөр, өөрөөр хэлбэл бид түүний өмнө шүүгдэхийн тулд зогсохоор авчрагдах тэр өдөр, тэрээр өөрийн үгийг бидэнд түгээж мөн түүгээрээ биднийг цэвэр болгосноос хойш бид илдээ ах дүүсийнхээ цусанд толботуулаагүйн гэрчлэл, тэдгээр нь Бурханд маань гэрчлэл болж, өнгөлөг хэвээрээ хадгалагдаж болохын тулд тэдгээрийг далдлан нууцгаая.

16 Мөн эдүгээ, ах дүүс минь, хэрэв бидний ах дүүс биднийг устгахыг эрэлхийлсэн ч гэсэн, болгоогтун, бид илднүүдээ зайлуулан нуух болно, тийм ээ, бүр тэдгээр нь эцсийн өдөр, бид тэдгээрийг хэзээ ч хэрэглээгүйн гэрчлэл болж өнгөлөг хэвээрээ хадгалагдаж болохын тулд газрын гүнд тэдгээрийг булшлах болно; мөн хэрэв ах дүүс маань биднийг устгах аваас, болгоогтун, бид Бурхандаа “очиж мөн аврагдах болно.

17 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор хаан эдгээр үгийг төгсгөж, мөн бүх хүмүүс цугларахад, тэд илднүүдээ, мөн хүмүүний цус урсгахын тулд хэрэглэгдэж байсан бүх зэр зэвсгээ авч, мөн тэдгээрийг газрын гүнд “булшлав.

18 Мөн үүнийг хийсэн нь тэд хэзээ ч хүмүүний цусыг урсгахаар зэр зэвсэг “дахин хэрэглэхгүй хэмээн Бурханд

мөн түүнчлэн хүмүүнд хандсан тэдний гэрчлэл мөн гэж тэд үзсэн ажээ; мөн тэд үүнийг хийж, мөн ах дүүсийнхээ цусыг урсгахын оронд тэд амиа “алдацгаах болно гэдгээ тэд Бурханд батламжлан мөн “гэрээлсэн бөлгөө; мөн ах дүүгээ авснаас түүний оронд тэд өгөх болно хэмээв; мөн өөрсдийн өдрүүдээ залхаг байдалд өнгөрөөсөнд орвол өөрсдийн гараар ихэд хөдөлмөрлөх болно хэмээв.

19 Мөн тийн бид, эдгээр леменчүүд итгэхэд мөн үнэнийг мэдэхэд авчрагдаж, тэд “тууштай байж, мөн нүгэл үйлдэхийн оронд бүр үхлийг хүртэл зовоход бэлэн байсныг харлаа; мөн тийн тэд энх амгалангийн зэр зэвсгээ, өөрөөр хэлбэл тэд дайны зэр зэвсгээ энх амгалангийн төлөө булшилсныг бид харлаа.

20 Мөнхүү улиран тохиох дор тэдний ах дүүс, леменчүүд, дайнд зориулан бэлтгэлүүдийг хийж, мөн хааныг устгах мөн түүний оронд өөрийг тавих, мөн түүнчлэн Антай-Нифай-Лихайн хүмүүсийг уг нутгаас гарган устгах зорилгоор Нифайн нутагт иржээ.

21 Эдүгээ хүмүүс өөрсдийнх нь эсрэг тэдний ирж буйг хараад тэдэнтэй уулзахаар тэд гарцгаав, мөн тэдний өмнө өөрсдийгөө газарт “сунан хэвтэхэд хүргэж мөн Их Эзэний

16a Алма 40:11–15.

17a Хил. 15:9.

18a Алма 53:11.

б су Золиослол.

в су Гэрээ.

19a су Итгэл.

21a Алма 27:3.

нэрийг дуудаж эхлэв; мөн тийн леменчүүд тэдний зүг дайран, мөн тэднийг илдээрээ алж эхлэхэд тэд ийм байдалтай байв.

22 Мөн тийн ямар ч эсэргүүцэлгүйгээр, тэдний нэгэн мянга тавыг нь алсан болой; мөн тэд адислагдсаныг бид мэднэ, учир нь тэд Бурхантайгаа оршихоор одсон билээ.

23 Эдүгээ леменчүүд өөрсдийнх нь ах дүүс илднээс зугтахгүй, бас баруун эсвэл зүүн гар тийш эргэхгүй байгааг, харин тэд хэвтэж мөн “эрсдэж, мөн Бурханыг, бүр илдэн дор эрсдэх яг тэр үедээ ч магтаж буйг хараад—

24 Эдүгээ леменчүүд үүнийг хараад тэд тэднийг алахаа “болив; мөн тэднээс олных нь зүрх сэтгэл илдэн дор унасан ах дүүсийнхээ төлөө ⁶тэгэлзэн байв, учир нь тэд хийсэн зүйлүүдийнхээ улмаас наманчилсан ажгуу.

25 Мөнхүү улиран тохиох дор тэд дайны зэвсгээ, мөн тэд тэдгээрийг дахин авмааргүйгээр доош хаяв, учир нь тэд өөрсдийн үйлдсэн аллагуудын улмаас зовиурлаж байв; мөн бүр тэднийг алахаар гараа далайсан өөрсдийнх нь нигүүлсэлд хандсан өөрсдийн ах дүүс мэт тэд доош сөхрөв.

26 Мөнхүү улиран тохиох дор тэр өдөр алагдсанаас Бурханы

илүү олон хүмүүс нэгтгэгдэв; мөн алагдсан тэд зөв шударга хүмүүс байв, тиймийн тул тэднийг “аврагдсанд эргэлзэх ямар ч шалтгаан бидэнд үгүй болой.

27 Мөн ёс бус хүн тэдний дунд алагдсангүй; харин мянгаас илүү олон нь үнэний мэдлэгт авчрагдав; тийн бид Их Эзэн өөрийн хүмүүсийн авралын төлөө олон “аргаар ажилладгийг харлаа.

28 Эдүгээ ах дүүсээсээ олныг алсан тэдгээр леменчүүдээс хамгийн олон тоотой нь амалекайчууд болон амюлончууд байв, тэдний ихэнх нь “нихорчуудын ⁶жаягийн дагуух хүмүүс байв.

29 Эдүгээ, Их Эзэний хүмүүст нэгдсэн тэдний дунд, амалекайчууд эсвэл амюлончууд, эсвээс Нихорын жаягийнхнаас “нэг ч байсангүй, харин тэд Лемен болон Лемүелийн жинхэнэ үр удам байв.

30 Мөн тийн аливаа хүмүүс нэгэнт Бурханы Сүнсээр “гэгээрүүлэгдсэний дараа, мөн зөв шударгад хамаарах зүйлсийн агуу ⁶мэдлэгтэй байсны дараа, мөн тэгээд нүгэл болон зөрчилд “унасан бол, тэд илүү хатуурч, мөн тийн тэдний байдал хэрэв тэд эдгээр зүйлийг хэзээ ч мэдээгүй байснаас ‘дор болдгийг бид тодорхойгоор олж харж чадна.

23a Алма 26:32.

24a Алма 25:1.

б су Өрөвч сэтгэл.

26a Илч. 14:13.

27a Иса. 55:8–9;

Алма 37:6–7.

28a Алма 1:15; 2:1, 20.

б Алма 21:4.

29a Алма 23:14.

30a Мат. 12:45.

б Евр. 10:26;

Алма 47:36.

в 2 Ниф. 31:14;

Алма 9:19.

су Урвалт.

г 2 Петр 2:20–21.

БҮЛЭГ 25

Леменчүүдийн түрэмгийлэл тархав—Ноагийн санваартнуудын үр удам Абинадайн бошиггосноор мөхөв—Олон леменчүүд хөрвүүлэгдэж мөн Антай-Нифай-Лихайн хүмүүстэй нэгдэв—Тэд Христэд итгэж мөн Мосегийн хуулийг дагав. Ойролцоогоор мээ 90–77 он.

Мөнхүү болгоогтун, эдүгээ улиран тохиох дор тэдгээр леменчүүд ах дүүсээ алсан учир илүү их ууртай байв; тиймийн тул тэд нифайчуудаас өс хонзон авахаар тангараглав; мөн тэд тэр цагт “Антай-Нифай-Лихайн хүмүүсийг алахаар дахин завдахаа болив.

2 Харин тэд их цэргээ авч мөн Зарахемла нутгийн хилийг давж, мөн Аммонайха нутагт байсан хүмүүсийг довтлон мөн тэднийг “устгав.

3 Мөн түүний дараа, тэд өөрсдөө туугдаж мөн алагдсан олон тулааныг нифайчуудтай хийв.

4 Мөн алагдсан леменчүүдийн дунд Ноагийн санваартнууд болох Амюлоны мөн тэдний ах дүүсийнх нь бараг бүх “үр удам байв, мөн тэд нифайчуудын гараар алагдсан байв;

5 Мөн үлдэгдэл нь, дорнын аглаг буйд тийш зугтаж, мөн тэд леменчүүдийн дээрх хүч

мөн эрх мэдлийг хууль бусаар булаан эзэлсэн учир, леменчүүдээс олон нь итгэлийнхээ учир галд “эрсдэхэд хүргэгдэв—

6 Учир нь “тэднээс олон нь их алдагдал хийгээд маш олон зовлонг хүлцсэний дараа, Аарон болон түүний ах дүүс тэдэнд өөрсдийнх нь нутагт номлосон “үгсийн санамжинд өдөөгдөж эхлэв; тиймийн тул тэд эцэг өвгөдийнхөө “уламжлалуудад итгэл алдарч, мөн Их Эзэнд, мөн тэрээр нифайчуудад агуу хүчийг өгсөн гэдэгт итгэж эхлэв; мөн тийн аглаг буйдад тэднээс олон нь хөрвүүлэгдэв.

7 Мөнхүү улиран тохиох дор “Амюлоны хүүхдүүдийн үлдэгдэл асан тэдгээр захирагчид тэднийг, тийм ээ, эдгээр зүйлд итгэсэн тэд бүгдийг “үхэлд хүргэв.

8 Эдүгээ энэ аллага тэдний ах дүүсээс олныг уур хилэнд өдөөн хатгагдах болгов; мөн аглаг буйдад зөрчилдөөн болж эхлэв; мөн леменчүүд Амюлоны мөн түүний ах дүүсийн үр удмыг “ангуучилж эхлэн мөн тэднийг хөнөөж эхлэв; мөн тэд дорнын аглаг буйд тийш зугтав.

9 Мөн болгоогтун тэд энэ өдөр ч леменчүүдээр ангуучлагдсаар байв. Галд эрсдэх түүний үхлийг амсах болго-

25 1а су Антай-Нифай-Лихайчууд.
2а Алма 8:16; 16:9.
4а Мозая 23:35.
5а Мозая 17:15.

6а ө.х. Леменчүүд.
б Алма 21:9.
в Алма 26:24.
7а Алма 21:3; 24:1, 28–30.
б су Санаатайгаар

алах, Санаатай аллага.
8а Мозая 17:18.

сон санваартнуудын үр удмын талаар хэлсэн Абинадайн үгс тийн улиран тохиосон болой.

10 Учир нь тэрээр тэдэнд хэлэв: Та нар надад юу “хийх нь ирэх зүйлүүдийн хэв шинж байх болно.

11 Мөн эдүгээ Абинадай Бурханд итгэх итгэлийнхээ учир галд эрсдэх “үхлийг үзсэн эхнийх нь байв; эдүгээ энэ нь түүний хэлсэн, түүний амссаны дагуу галаар эрсдэх үхлийг олон хүн амсах болно гэсэн утгатай ажээ.

12 Мөн тэрээр Ноагийн санваартнуудад ийн хэлжээ, тэдний үр удам олныг түүний нэгэн адил маягаар үхэлд хүргэх болно, мөн тэд тараагдаж мөн алагдаж, бүр хоньчингүй хонь мэт туугдаж мөн зэрлэг араатнуудаар алагдах лугаа адил буюу; мөн эдүгээ болгоогтун, эдгээр үг нотлогдсон билээ, учир нь тэд леменчүүдээр туугдаж, мөн тэд ангуучлагдсан, мөн тэд цохигдсон бөлгөө.

13 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд нифайчуудыг захиран дийлж эс чадахаа үзээд нутагтаа дахин эргэж ирсэн; мөн тэдний олон нь Ишмэилийн нутагт мөн Нифайн нутагт оршихоор ирж, мөн өөрсдийгөө “Антай-Нифай-Лихайн хүмүүс болох, Бурханы хүмүүстэй нэгтгэв.

14 Мөн тэд ах дүүсийнхээ

хийсний дагуу, дайны зэр зэвсгүүдээ түүнчлэн “булшилж, мөн тэд зөв шударга хүмүүс болж эхлэв; мөн тэд Их Эзэний замаар алхалж, мөн түүний зарлигуудыг хийгээд түүний дүрмүүдийг дагахаар эрмэлзсэн билээ.

15 Тийм ээ, мөн тэд Мосегийн хуулийг дагадаг байв; учир нь тэд тухайн үед бүгд гүйцэлдээгүй байсан учраас “Мосегийн хуулийг дагах нь зайлшгүй байв. Харин Мосегийн хууль байсан хэдий ч, Мосегийн хууль нь түүний ирэлтийн ^бхэв шинж байсан хэмээн бодож, мөн тэрээр тэдэнд илчлэгдэх тэр цагийг хүртэл “гадна талын ёслолуудыг дагах ёстой гэдэгт итгэсэн учир тэд Христийн ирэлтийг харуулдан хүлээж байв.

16 Эдүгээ тэд “Мосегийн хуулиар ^баврал ирнэ гэж бодсонгүй; харин Мосегийн хууль нь Христэд итгэх тэдний итгэлийг хүчирхэгжүүлэхэд үйлчилдэг байв; мөн ирэх тэдгээр зүйлүүдийн тухай ярьсан бошиглолын суу билэг дээр тэд тулгуурлан, мөн тийн тэд мөнхийн авралд хүргэх “найдварыг хадгалдаг байв.

17 Мөн эдүгээ болгоогтун, Аммон, мөн Аарон, мөн Омнер, мөн Химнай, мөн тэдний ах дүүс үлэмж баяссаны учир нь Их Эзэн өөрсдийнх нь

10a Мозая 13:10.

11a Мозая 17:13.

13a Алма 23:16–17.

14a Алма 24:15; 26:32.

15a Иаков 4:5;

Жером 1:11.

су Мосегийн хууль.

б Мозая 3:14–15; 16:14.

в Мозая 13:29–32.

16a 2 Ниф. 11:4.

б Мозая 12:31–37;

13:27–33.

в 1 Тес. 5:8–9.

“залбирлуудын дагуу тэдэнд өгсөн леменчүүдийн дундах тэдний амжилт, мөн түүнчлэн тэрээр өөрийн үгсийг тэдэнд зүйл бүр дээр нь нотолсных бөлгөө.

БҮЛЭГ 26

Аммон Их Эзэнийг бахархан магтав—Итгэлтнүүд Их Эзэнээр хүчирхэгжүүлэгдэж мөн мэдлэг өгөгддөг—Хүмүүн итгэлээр мянга мянган бодгалийг наманчлалд авчирч болно—Бурхан бүх хүч чадлыг эзэмшиж мөн бүх зүйлийг ухаардаг. Ойролцоогоор мээ 90–77 он.

Мөн эдүгээ, эдгээр нь ах дүүсдээ хандсан Аммоны үгс болой, ийн хэлэв: Ах дүүс минь мөн нөхөд минь, болгоогтун би та нарт хэлнэ, бидэнд баясаж болох ямар агуу шалтгаан байнав; учир нь бид Зарахемла нутгаас “эхлэхдээ Бурхан бидэнд ийм их адислалуудыг өгөх болно гэдгийг бодож чадаж байсан гэж үү?

2 Мөн эдүгээ, би асууна, бидний дээр ямар агуу адислалуудыг тэр соёрхсон билээ? Та нар хэлж чадах уу?

3 Болгоогтун, би та нарт хариулна; тухайлбал бидний ах дүүс, леменчүүд, харанхуйд, тийм ээ, бүр хамгийн харанхуй ангалд байсан, гэвч

болгоогтун, тэднээс хичнээн “олон нь Бурханы гайхамшигт гэрлийг болгоохоор авчрагдсан билээ! Мөн бид энэ агуу ажлыг гүйцэлдүүлэхэд Бурханы мутар дахь ^бзэмсгүүд болгогдсон нь, бидний дээр бэлэглэгдсэн адислал болой.

4 Болгоогтун, тэдний “мянга мянга нь баясна, мөн Бурханы сүрэгт авчрагдсан болой.

5 Болгоогтун, “талбай боловсорч гүйцсэн байв, мөн адислагдсан болой та нар, учир нь та нар ^бхадуураа барьж, мөн чадлаараа хадсан, тийм ээ, бүхэл өдрийн турш та нар хөдөлмөрлөсөн; мөн ^ббоодлуудынхаа тоог болгоогтун! Мөн тэдгээр нь үрэгдэхгүйн тулд тариа хадгалах газруудад хураагдах болно.

6 Тийм ээ, тэд эцсийн өдөр шуурганд цохигдохгүй; тийм ээ, тэдгээр нь салхин хүрдэнд ч автагдахгүй; харин “шуурга ирэхэд, шуурга тэднийг нэвтэлж чадахгүйн тул тэдгээр нь байрандаа нэгдэн цуглуулагдах болно; тийм ээ, бас тэд дайсны хүссэн хаана боловч тэдгээрийг аваачих догшин салхинд туугдахгүй бөлгөө.

7 Гэвч болгоогтун, тэд “ургацын Их Эзэний мутарт байна, мөн тэд түүнийх билээ; мөн тэрээр эцсийн өдөр тэднийг ^ббосгох болно.

17a Алма 17:9.

26 1a Мозая 28:9;
Алма 17:6–11.

3a Алма 23:8–13.

б 2 Кор. 4:5;

Мозая 23:10.

4a Алма 23:5.

5a Иохан 4:35–37;

С ба Г 4:4.

б Иоел 3:13.

в С ба Г 33:7–11; 75:2, 5.

6a Хил. 5:12;

3 Ниф. 14:24–27.

7a су Ургац хураалт.

б Мозая 23:22;

Алма 36:28.

8 Бурханы минь нэр алдаршиг; түүнийг магтахад “дуугаа өргөцгөөе, тийм ээ, түүний ариун нэрэнд ^бталархал өргөө, учир нь тэр зөв шударгын ажлыг үүрд үйлддэг билээ.

9 Тухайлбал хэрэв бид Зарахемла нутгаас ирээгүй бол, биднийг ийм эрхмээр хайрласан, эдгээр эрхэм хайрт ах дүүс маань бидний эсрэг “үзэн ядалтандаа тарчилсаар байх байсан, тийм ээ, мөн тэд түүнчлэн Бурханы хувьд танихгүй хүмүүс байх сан билээ.

10 Мөнхүү улиран тохиох дор Аммон эдгээр үгсийг хэлэхэд, түүний ах Аарон түүнийг зэмлэн, хэлэв: Аммон, баясал чинь чамайг бардамнан сагсуурахад хүргэлээ хэмээн би айх юм.

11 Гэвч Аммон түүнд хэлрүүн: Би өөрийн хүч чадалд, бас өөрийн мэргэн ухаанд ч “бардамнан сагсуураагүй байна; гэвч болгоогтун, миний баясал дүүрч, тийм ээ, зүрх сэтгэл минь ^ббаяслаар халгинам, мөн би Бурхандаа баярлах болно.

12 Тийм ээ, би юу ч биш гэдгээ мэднэ; чадлынхаа хувьд би сул дорой; тиймийн тул би өөрөөрөө “бардамнахгүй, харин би Бурханаараа бардамнах болно, учир нь түүний

^бхүч чадалд би бүх зүйлийг хийж чадна; тийм ээ, болгоогтун, олон хүчит гайхамшигийг бид энэ нутагт гүйцээсэн, үүнийхээ учир би түүний нэрийг үүрд алдаршуулах болно.

13 Болгоогтун, тэрээр хичнээн мянган ах дүүсийг минь тамын “шаналлаас сулласан билээ; мөн тэд ^бгэтэлгэлийн хайрыг дуулахад хүргэгддэг, мөн энэ нь бидэнд байдаг түүний үгийн хүчний учир юм, тиймийн тул баясах агуу шалтгаан бидэнд байхгүй гэж үү?

14 Тийм ээ, бидэнд түүнийг үүрд алдаршуулах шалтгаан буй, учир нь тэр бол Бүхний Дээд Бурхан, мөн ах дүүсийг маань тамын “гинжнээс сулласан болой.

15 Тийм ээ, тэд үүрдийн харанхуй мөн устгалаар хүрээлэгдсэн байлаа; гэвч болгоогтун, тэрээр өөрийн үүрдийн “гэрэлд, тийм ээ, үүрдийн авралд тэднийг авчирсан; мөн тэд түүний зүйрлэшгүй өгөөмөр хайраар хүрээлэгдсэн билээ; тийм ээ, мөн бид энэ агуу хийгээд гайхамшигт ажлыг хийхэд түүний мутардахь зэмсгүүд байсан билээ.

16 Тиймийн тул, “бахархацгаая, тийм ээ, бид Их Эзэнээр ^ббахархах болно; тийм ээ, бид

8а С ба Г 25:12.

б су Талархалтай,
Талархах, Талархал
өргөх.

9а Мозая 28:1–2.

11а 2 Кор. 7:14.

б С ба Г 18:14–16.

су Баяр баясгалан.

12а Иер. 9:24; Алма 29:9.

б Дуул. 18:32–40;

Филип. 4:13;

1 Ниф. 17:3.

13а су Там.

б Алма 5:26.

14а Алма 12:11.

15а су Гэрэл, Христийн
гэрэл.

16а Ром 15:17;

1 Кор. 1:31.

б 2 Кор. 10:15–18;

С ба Г 76:61.

баясах болно, учир нь бидний баясал дүүрэн байна; тийм ээ, бид Бурханаа үүрд магтан дуулах болно. Болгоогтун, хэн Их Эзэнд хэтэрхий их алдрыг өргөж чадах билээ? Тийм ээ, түүний агуу их хүчний тухай, мөн түүний “нигүүлслийн тухай, мөн хүмүүний үрсэд хандах түүний гэсвэрийн тухай хэн хэтэрхий ихийг хэлж чадах билээ? Болгоогтун, би та нарт хэлнэ, би өөрийн мэдэрч байгаагийнхаа хамгийн бага хэсгийг ч хэлж чадахгүй.

17 Бурхан маань биднийг өөрсдийн маань аймшигт, нүгэлт мөн бузартсан байдлаас шүүрч авахаар тийм нигүүлсэнгүй хэмээн хэн бодох билээ?

18 Болгоогтун, бид бүр уур хилэгнэлтэйгээр, түүний сүмийг “устгах гэсэн хүчит заналхийлэлтэйгээр урагшлан явсан билээ.

19 Ай тэгээд, яагаад тэрээр биднийг аймшигт устгалд оногдуулсангүй вэ, тийм ээ, яагаад тэрээр өөрийн шударга ёсны илдийг бидний дээр буулгасангүй вэ, мөн биднийг мөнхийн цөхрөлд ялласангүй вэ?

20 Ай, сүнс минь, бараг л ингэж бодохоос зайлсхиймээр байна. Болгоогтун, тэрээр өөрийн шударга ёсыг бидний дээр эс хэрэгжүүлэн, харин

агуу их нигүүлсэлдээ биднийг тэр үүрдийн үхлийн мөн аймшгийн “ангалаас хэлтрүүлж, бүр бидний сүнсний авралд авчирсан билээ.

21 Мөн эдүгээ болгоогтун, ах дүүс минь, эдгээр зүйлийг мэддэг ямар “эгэл хүн байдаг билээ? Би та нарт хэлнэ, нүглээ наманчлагч байхаас бусдаар, эдгээр зүйлийг “мэддэг нэгээхэн ч үгүй бөлгөө.

22 Тийм ээ, “наманчилдаг мөн “итгэлээ бодитой болгодог, мөн сайн үйлүүдийг авчирдаг, мөн үргэлж тасралтгүйгээр залбирдаг түүнд — ийм нэгэнд “Бурханы нууцууд мэдэгдэхээр өгөгдсөн байдаг; тийм ээ, хэзээ ч илчлэгдэж байгаагүй зүйлүүд илчлэгдэхээр ийм нэгэнд өгөгдөх болно; тийм ээ, мөн мянга мянган бодгалийг наманчлалд авчрах нь, бүр өөрсдийн эдгээр ах дүүсийг наманчлалд авчрах нь бидэнд өгөгдсөний адилаар ийм нэгэнд өгөгдөх болно.

23 Эдүгээ ах дүүс минь, бид Зарахемла нутагт ах дүүстээ, бид Нифайн нутагт ах дүүс леменчүүддээ номлохоор очихыг хэлэхэд, мөн тэд биднийг элэглэн дооглож инээлдсэнийг та нар санаж байна уу?

24 Учир нь тэд бидэнд хэлэв: Та нар леменчүүдийг үнэний мэдлэгт авчирч чадна хэмээн бодно уу? Та нар цус

16в Дуул. 36:5–6.
18а Мозая 27:8–10.
20а 2 Ниф. 1:13;
Хил. 3:29–30.
21а су Эгэл хүн.

б 1 Кор. 2:9–16;
Иаков 4:8.
22а Алма 36:4–5.
су Наманчлах,
Наманчлал.

б су Итгэл.
в су Бурханы
нууцууд.

урсгахдаа зүрх нь баясах тэднийг; өдрүүд нь хамгийн бузар алдсуудад өнгөрсөн тэднийг; зам нь эхлэлээс л зөрчигчийн зам байсан тэднийг, тэр чигээрээ “зөрүүд хүмүүс, леменчүүдэд эцэг өвгөдийнх нь” заншил зөв бус гэдэгт тэднийг үнэмшүүлэн ухааруулж чадна хэмээн бодно уу? Эдүгээ ах дүүс минь, энэ нь тэдний үгс байсныг та нар санаж байгаа.

25 Мөн үүнээс гадна тэд хэлэв: Тэдний эсрэг зэвсэглэцгээе, тэд биднийг дийлж мөн биднийг устгахгүйн тулд бид тэднийг мөн тэдний алдсуудыг уг нутгаас устгах болно.

26 Гэвч болгоогтун, хайрт ах дүүс минь, бид аглаг буйдад ах дүүсээ устгах зорилготойгоор бус харин тэдний бодгалиудаас цөөн хэдийг боловч аварч болох магад хэмээх зорилготойгоор ирсэн билээ.

27 Эдүгээ бидний зүрх шантарч, мөн бараг л буцах гэж байхад, болгоогтун, Их Эзэн биднийг “тайтгаруулан, мөн хэлэв: Өөрсдийн ах дүүс, леменчүүдийн дунд явагтун, мөн “зовлонгуудаа” тэвчээртэйгээр туул, мөн би та нарт амжилтыг өгөх болно гэсэн бөлгөө.

28 Мөн эдүгээ болгоогтун, бид ирж, мөн тэдний дунд орсон; мөн бид зовлонгууддаа тэвчээртэй байв, мөн бид гачигдал бүрийг туулсан

бөлгөө; тийм ээ, дэлхийн нигүүлсэл дээр—зөвхөн дэлхийн нигүүлсэл дээр ч бус харин түүнчлэн Бурханы нигүүлсэл дээр тулгуурлан бид байшингаас байшин хүртэл аялсан.

29 Мөн бид тэдний гэрт орж мөн тэдэнд зааж, мөн тэдэнд гудамжинд нь сургаж байв; тийм ээ; мөн бид толгод дээр тэдэнд зааж байв; мөн түүнчлэн бид тэдний ариун сүмүүдэд мөн тэдний синагогуудад орж мөн тэдэнд заасан; мөн бид хөөгдөж, мөн элэглэгдэж, мөн нулимуулж, мөн хацар дээрээ цохиулж байлаа; мөн бид чулуугаар шидүүлж, мөн баривчлагдаж мөн бөх олсоор хүлэгдэж, шоронд хаягдаж байв; мөн Бурханы хүч мөн мэргэн ухаанаар бид дахин чөлөөлөгдөж байсан болой.

30 Мөн бид бүх л төрлийн зовлонгуудыг, мөн энэ бүгдийг, бид зарим нэг бодгалийг аврах хэрэгсэл байж болох магад хэмээн туулсан билээ; мөн хэрэв бид магад зарим хэдийг аврах хэрэгсэл байж чадвал бидний “баясал дүүрэн байна хэмээн бодсон” буюу.

31 Эдүгээ болгоогтун, бид урагш харж мөн хөдөлмөрийнхөө үр жимсийг харж чадна; мөн тэдгээр нь цөөхөн гэж үү? Би та нарт хэлнэ, Үгүй, тэдгээр нь “олон; тийм ээ, мөн бид тэдний чинхүү

24a Мозая 10:11–17.

б Мозая 13:29.

27a Алма 17:9–11.

б Алма 20:29–30.

сү Дайсан.

в сү Тэвчээр.

30a С ба Г 18:15–16.

31a Алма 23:8–13.

сэтгэлийг харж чадна, ах дүүстээ хандсан, мөн түүнчлэн бидэнд хандсан тэдний хайрын учир болой.

32 Учир нь болгоогтун, тэд бүр дайсныхаа амийг авснаас өөрсдийн амийг “золиосолсон нь дээр хэмээсэн болой; мөн тэд дайны зэр зэвсгүүдээ газрын гүнд ⁶булшилсан, ах дүүстээ хандсан тэдний хайрын учир болой.

33 Мөн эдүгээ болгоогтун би та нарт хэлнэ, бүх нутагт ийм агуу их хайр байсан уу? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй, байгаагүй, бүр нифайчуудын дунд ч гэсэн тэр.

34 Учир нь болгоогтун, тэд ах дүүсийнхээ эсрэг зэвсгээ агсахад бэлэн байсан; тэд өөрсдийгөө алуулахыг тэвчээгүй. Гэвч болгоогтун тэдний хичнээн олон нь амиа өгсөн билээ; мөн өөрсдийн хайр мөн нүгэлд хандах хонзогнолынхоо учир тэд өөрсдийн Бурханд одсоныг бид мэднэ.

35 Эдүгээ бидэнд баясах шалтгаан үгүй гэж үү? Тийм ээ, би та нарт хэлнэ, дэлхий эхэлснээс хойш бидний адил ийм агуу баясах шалтгаантай хүмүүн хэзээ ч байгаагүй; тийм ээ, мөн баясал минь бүр Бурханаараа бардамнах бардамналд хүргэв; учир нь түүнд бүх “хүч чадал, бүх мэргэн ухаан, мөн бүх ойлголт байдаг; тэрээр бүх зүйлийг

⁶ухаардаг мөн наманчлах мөн түүний нэрэнд итгэдэг тэднийг бүр авралд хүргэх тэрээр “нигүүлсэнгүй Нэгэн бөлгөө.

36 Эдүгээ хэрэв энэ нь бардамнал аваас, тэрчлэн би бардамнах болно; учир нь энэ бол миний амьдрал мөн миний гэрэл, миний баясал бөгөөд миний аврал, мөн үүрдийн халгаас гэтэлгэх миний гэтэлгэл. Тийм ээ, мөн харь нутагт биеэсээ гээгдсэн Израилын модны “мөчир болох энэ хүмүүст анхааран хандсан Бурханы минь нэр алдаршсан болой; тийм ээ, би хэлнэ, Бурханы минь, харь газар ⁶бэдрэх биднийг анхаарч үзсэн, түүний нэр алдаршиг.

37 Эдүгээ ах дүүс минь, тэд аль ч нутагт байсан “хүмүүс болгоныг Бурхан анхааран үздэгийг бид харлаа; тийм ээ, тэрээр өөрийн хүмүүсийг тоолж, мөн нигүүлслийнх нь зүрх сэтгэл бүх дэлхийг бүрдэг билээ. Эдүгээ энэ нь миний баясал, мөн миний агуу талархал; тийм ээ, мөн Бурхандаа би үүрд талархах болно. Амен.

БҮЛЭГ 27

Антай-Нифай-Лихайн хүмүүсийг аюулгүй байдал тийш удирдахыг Их Эзэн Аммонд зарлиглав— Алматай уулзах үед Аммоны баясал хүчийг нь туйлдуулав—

32a Алма 24:20–24.

б Алма 24:15.

35a су Хүч.

б С ба Г 88:41.

в су Нигүүлсэнгүй,

Нигүүлсэл.

36a Эхл. 49:22–26;

Иаков 2:25; 5:25.

б Иаков 7:26.

37a Үйлс 10:34–35;

2 Ниф. 26:33.

Нифайчууд Антай-Нифай-Лихайчуудад Жершоны нутгийг өгөв—Тэд Аммоны хүмүүс гэж нэрлэгдэв. Ойролцоогоор мээ 90–77 он.

Эдүгээ улиран тохиох дор нифайчуудын эсрэг дайтахаар явсан леменчүүд, тэднийг устгах гэсэн олон оролдлогынхоо дараа тэднийг устгахыг эрэлхийлэх нь дэмий болохыг олж мэдээд, тэд Нифайн нутагт дахин эргэж очив.

2 Мөнхүү улиран тохиох дор амалекайчууд, гарз хохирлынхоо учир, үлэмж ууртай байв. Мөн тэд нифайчуудаас өшөө авч чадаагүйгээ үзээд, тэд өөрсдийнх нь “ах дүүс болох ⁶Антай-Нифай-Лихайн хүмүүсийн эсрэг уур хилэнд хүмүүсийг өдөөн хатгаж эхлэв; тиймийн тул тэд дахин тэднийг устгаж эхлэв.

3 Эдүгээ энэ хүмүүс зэвсгээ агсахаас “дахин татгалзаж мөн дайснуудынхаа хүслийн дагуу өөрсдийгөө алуулахыг тэд хүлцэв.

4 Эдүгээ Аммон мөн түүний ах дүүс, өөрсдийнх нь тэгж дотноор хайрласан, мөн өөрсдийг нь тэгж дотноор хайрласан—учир нь тэд бол Бурханаас тэднийг үүрдийн устгалаас аврахаар илгээгдсэн тэнгэр элчүүд лугаа адил тэдэнд хандаж байв—тэдний дундах устгалын энэхүү ажлыг хараад, тиймийн тул,

Аммон болон тэдний ах дүүс устгалын агуу ажлыг хараад тэд өрөвдөн догдолж, мөн тэд хаанд “хэлэв:

5 Их Эзэний энэ хүмүүсийг нэгтгэн цуглуулцгаая, мөн Зарахемлагийн нутаг дахь бидний ахан дүүс нифайчууд уруу явж, мөн бид устгагдахгүйн тул дайснуудынхаа гараас зугтан гарцгаая.

6 Гэвч хаан тэдэнд хэлэв: Болгоогтун, тэдний эсрэг бидний үйлдсэн олон аллага мөн нүглүүдийн учир нифайчууд биднийг устгах болно.

7 Мөн Аммон хэлэв: Би явж мөн Их Эзэнээс лавлах болно, мөн хэрэв тэр биднийг ах дүүсдээ оч хэмээвэл, та нар явах уу?

8 Мөн хаан түүнд хэлэв: Тийм ээ, хэрэв Их Эзэн бидэнд явахыг хэлбэл, бид ах дүүс уруугаа явах болно, мөн тэдний эсрэг өөрсдийн үйлдсэн олон аллага хийгээд нүглүүдээ тэдэнд залруулах хүртлээ бид тэдний боол байх болно.

9 Гэвч Аммон түүнд хэлэв: Энэ бол ах дүүсийн маань, тэдний дунд нэг ч “боол байх ёсгүй гэсэн миний эцгээр тогтоогдсон хуулийн эсрэг болой; тиймийн тул тийш явцгааж мөн ах дүүсийнхээ нигүүлсэл дээр түшиглэе.

10 Гэвч хаан түүнд хэлэв: Их Эзэнээс лавла, мөн хэрэв тэр бидэнд явахыг хэлбэл, бид

27 2a Алма 43:11.

б Алма 25:1.

су Антай-Нифай-

Лихайчууд.

3a Алма 24:21–26.

4a Алма 24:5.

9a Мозая 2:13;

29:32, 38, 40.

явах болно; өөрөөр бол бид нутагтаа мөхөх болно.

11 Мөнхүү улиран тохиох дор Аммон одож мөн Их Эзэн нээс лавлав, мөн Их Эзэн түүнд хэлэв:

12 Тэд мөхөхгүйн тулд энэ хүмүүсийг авч энэ нутгаас гарга; учир нь ах дүүсийнх нь эсрэг уурлуулж мөн тэднийг алуулахаар леменчүүдийг өдөөн хатгаж буй амалекайчуудын зүрхэнд Сатан агуу байр эзэлжээ; тиймийн тул та энэ нутгаас гарч яв; мөн энэ хүмүүс энэ үедээ адислагдсан билээ, учир нь би тэднийг хадгалан хамгаалах болно.

13 Мөн эдүгээ улиран тохиох дор Аммон явж мөн хаанд Их Эзэн түүнд хэлсэн тэр бүхий л үгсийг хэлэв.

14 Мөн тэд өөрсдийн бүх хүмүүсийг нэгтгэн цуглуулж, тийм ээ, Их Эзэний бүх хүмүүсийг, мөн тэдний бүх бог болон бод малыг нэгтгэн цуглуулж, мөн уг нутгаас гарч, мөн Нифайн нутгийг Зарахемлагийн нутгаас зааглан хуваадаг аглаг буйдад ирж, мөн нутгийн хилийн ойролцоо ирэв.

15 Мөнхүү улиран тохиох дор Аммон тэдэнд хэлэв: Болгоогтун, би түүнчлэн миний ах дүүс Зарахемлагийн нутаг тийш явах болно, мөн та нар биднийг эргэж иртэл эндээ үлдэх болно; мөн бид ах дүүсийнхээ сэтгэлийг сонжин тэд та нарыг нутагтаа оруу-

лахыг хүсэх эсэхийг мэдэх болно.

16 Мөнхүү улиран тохиох дор Аммон уг нутагт орж явахдаа, өмнө нь дурдагдсан тэрхүү “газарт тэр болон түүний ах дүүс Алматай тааралдав; мөн болгоогтун, энэ нь баярт уулзалт байв.

17 Эдүгээ Аммоны “баясал нь, бүр тэрбээр дүүрэн байсан тийм агуу байв; тийм ээ, тэрбээр бүр хүч нь “тамирдах хүртэл Бурхандаа баясах баясалд халгилж байв; мөн тэр “дахин газар уналаа.

18 Эдүгээ энэ нь үлэмжийн баясал байсан бус уу? Болгоогтун, энэ нь үнэнээр гэмшигчээс хийгээд баяр баясгаланг даруухнаар эрэлхийлэгчээс өөр хэн ч хүлээн авахгүй тэр баясал болой.

19 Эдүгээ Алмагийн ах дүүс тэйгээ уулзсан баясал, мөн түүнчлэн Аароны, Омнерийн мөн Химнайн баясал үнэхээр агуу их байв; гэвч болгоогтун тэдний баясал тэдний хүчийг тамирдуулахаар тийм байсангүй.

20 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма ах дүүсээ Зарахемлагийн нутаг тийш; бүр өөрийнхөө гэрийг хүртэл буцаан удирдав. Мөн тэд явж мөн, Нифайн нутагт, өөрсдийн ах дүүс леменчүүдийн дунд тэдэнд юу тохиолдсон бүх зүйлийг “ерөнхий шүүгчид хэлэв.

21 Мөнхүү улиран тохиох дор Антай-Нифай-Лихайн хүмүүс

асан ах дүүсээ оруулах талаар хүмүүсийн саналыг ерөнхий шүүгч хүсэн бүх нутаг даяар зар илгээв.

22 Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн санал ирэв, өгүүлсэн нь: Болгоогтун, бид дорнодод тэнгисийн тэнд байдаг, Өгөөмөр нутагтай хиллэдэг, Өгөөмөр нутгийн өмнөдөд байдаг Жершоны нутгийг өгөх болно; мөн бидний ах дүүсдээ өв залгамжлуулан өгөх нутаг нь Жершоны нутаг болой.

23 Мөн болгоогтун, бид Жершоны нутагт ах дүүсээ хамгаалж болохын тулд бид их цэргээ Жершоны нутаг болон Нифайн нутгийн хооронд байрлуулах болно; мөн ах дүүсийнхээ эсрэг зэвсэг агсаж нүгэл үйлдэхээс эмээх айдсын улмаас ах дүүсийнхээ төлөө бид үүнийг хийнэ; мөн энэ агуу айдас нь тэдний олон аллага мөн тэдний аймшигт ёс бус явдлын улмаас, үйлдсэн тэрхүү шаналалт наманчлалын улмаас ирсэн болой.

24 Мөн эдүгээ болгоогтун, тэд Жершоны нутгийг өвлөж болохын тулд бид ах дүүсдээ үүнийг хийх болно; мөн бидэнд, бид их цэрэгтээ дэмжлэг үзүүлж болохын тулд тэд бидэнд туслан хөрөнгөнийхөө хэсгээс өгөх нөхцөлд бид тэднийг дайснуудаас нь их цэргээрээ хамгаалах болно.

25 Эдүгээ, улиран тохиох дор Аммон үүнийг сонсоод, тэр

Антай-Нифай-Лихайн хүмүүст, мөн түүнчлэн Алма түүнтэй хамт, аглаг буйд тийш тэдний майхнуудаа босгосон газар эргэж очиж, мөн тэдэнд эдгээр бүх зүйлийг мэдүүлэв. Мөн Алма түүнчлэн өөрийн Аммон, Аарон хоёр, бас түүний ах дүүстэй хамт “хөрвүүлэгдсэнээ тэдэнд өгүүлэв.

26 Мөнхүү улиран тохиох дор энэ нь тэдний дунд агуу баясал авчрав. Мөн тэд Жершоны нутагт уруудан очиж, мөн Жершоны нутгийг эзэмшилдээ авав; мөн тэд нифайчуудаар Аммоны хүмүүс гэж нэрлэгдэв; тиймийн тул тэд уг нэрээр цаашид ялгарах болов.

27 Мөн тэд Нифайн хүмүүсийн дунд байж, мөн түүнчлэн Бурханы сүмд байсан хүмүүсийн дунд тоологдов. Мөн тэд түүнчлэн Бурханд хандсан, мөн түүнчлэн хүмүүст хандсан өөрсдийн хичээл зүтгэлээр онцгойлогдсон байв; учир нь тэд бүх зүйлд төгс “шударга мөн зөв шулуун байв; мөн тэд Христэд итгэх итгэлдээ бүр эцсээ хүртэл ^бгуйвшгүй байв.

28 Мөн тэд ах дүүсийнхээ цус урсгахыг хамгийн их жигшил зэвүүцэлтэйгээр хардаг байв; мөн тэд хэзээ ч ах дүүсийнхээ эсрэг зэвсэг агсахаар ятгагдаж байсангүй; мөн тэд үхлийг ямар нэгэн аймшиг хэмээн бодохоо больжээ, Христийн тухай болон амилуулалтын

тухай найдвар ойлголтын учир болой; тиймийн тул, тэдний хувьд үхэл нь, үүнийг давсан Христийн ялалтаар үгүйсгэгдсэн билээ.

29 Тиймийн тул, тэднийг цохихоор илдээ эсвэл сэлмээ тэд барихаасаа өмнө тэд өөрсдийн ах дүүсээр учруулагдаж болох хамгийн гамшигт хийгээд зүдгүүрт “үхлийг тэвччид бэлэн байв.

30 Мөн тийн тэд хичээнгүй мөн хайрлагдсан хүмүүс, Их Эзэн ихээр таалсан хүмүүс байв.

БҮЛЭГ 28

Леменчүүд аймшигт тулаанд ялагдав—Хэдэн арван мянга нь алагдав—Ёс бусыг үйлдэгсэд төгсгөлгүй гаслангийн байдалд тохоогдсон байдаг; зөв шударгыг үйлдэгчид хэзээ ч үл төгсөх аз жаргалд хүрэх болно. Ойролцоогоор мээ 77–76 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Аммоны хүмүүс Жершоны нутагт суурьшсаны, мөн түүнчлэн “Жершоны нутагт сүм байгуулагдсаны, мөн нифайчуудын их цэрэг Жершоны нутгийн эргэн тойронд тийм ээ, Зарахемлагийн нутгийн бүх хилийг хүрээлэн байрлуулагдсаны дараа; болгоогтун леменчүүдийн их цэрэг ах дүүсээ аглаг буйдад мөрдсөн ажээ.

2 Мөн тийн аймшигт тулаан

болов; тийм ээ, бүр Лихай Иерусалимыг орхисон тэр цагаас уг нутагт бүх хүмүүний дунд хэзээ ч мэдэгдэж байгаагүй тийм тулалдаан болов; тийм ээ, мөн леменчүүдийн хэдэн арван мянга нь алагдан мөн тараан сарниулагдав.

3 Тийм ээ, мөн түүнчлэн Нифайн хүмүүсийн дунд ч аймшигт аллага болов; гэсэн хэдий ч, леменчүүд “туугдан мөн сарниулагдаж, мөн Нифайн хүмүүс нутагтаа эргэж ирэв.

4 Мөн эдүгээ энэ нь бүх нутаг даяар Нифайн бүх хүмүүсийн дунд агуу гашуудал болон харуусал сонсогдсон нэгэн үе байв—

5 Тийм ээ, бэлэвсэн эхнэрүүд нөхрүүдийнхээ төлөө, мөн түүнчлэн эцгүүд хөвгүүдийнхээ төлөө, мөн охид ах нарынхаа төлөө, тийм ээ, хөвгүүд нь эцгүүдийнхээ төлөө гашуудан уйлж байв; мөн тийн алагдсан төрлүүдийнхээ төлөө гашуудан уйлах нь сонсогдож байв.

6 Мөн эдүгээ энэ нь гунигтай өдөр байсан нь гарцаагүй; тийм ээ, гашуудлын үе, мөн их “мацаг барилт хийгээд залбирлын үе болой.

7 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арвантав дахь он төгсөв;

8 Мөн энэ нь Аммон болон түүний ах дүүсийн, Нифайн

нутаг дахь тэдний аялал, уг нутаг дахь тэдний зовлон, тэдний харуусал, мөн тэдний зүдрэлүүдийн, мөн тэдний “ухааршгүй их баяслын, мөн Жершоны нутаг дахь ах дүүсийнх нь хүлээн авалт мөн аюулгүй байдлын шастир болой. Мөн эдүгээ бүх хүмүүний Гэтэлгэгч Их Эзэн тэдний бодгалиудыг үүрд адислах болтугай.

9 Мөн энэ нь нифайчуудын дундах дайн ууд хийгээд тэмцлүүдийн, мөн түүнчлэн нифайчууд болон леменчүүдийн хоорондох дайнуудын шастир болой; мөн шүүгчдийн засаглалын арвантагдахь он төгсөв.

10 Мөн анхны оноос арвантагдахь хүртэлх хугацаанд олон мянган амь эрсдэлт улиран тохиожээ; тийм ээ, үүнд нь аймшигт цус урсалтын үзэгдэл улиран тохиожээ.

11 Мөн олон мянгын цогцос газрын гадаргуу дээр овоорон ялзарч байхад олон мянгын цогцос “газар дор тавигдаж; тийм ээ, мөн олон мянга нь төрөл төрөгсдөө алдсандаа ^бгашуудаж байв, учир нь Их Эзэний амлалтуудын дагуу, тэд төгсгөлгүй гаслангийн байдалд тохоогджээ хэмээн айх шалтгаан тэдэнд буй.

12 Өөр олон мянга нь төрөл төрөгсдөө алдсандаа үнэхээр гашуудан байх зуураа, гэсэн ч тэд Бурханы баруун гар талд

оршихоор, хэзээ ч төгсөхгүй аз жаргалын байдалд босгогдсоныг Их Эзэний “амлалтуудын дагуу тэд найдвартаа баясан мөн хөөрч, мөн бүр мэдэж байв.

13 Мөн тийн хүмүүний зүрх сэтгэлийг урхидахаар зохиосон түүний зальт “төлөвлөгөөнүүдээр ирэх тэр нүгэл болон зөрчлийн, мөн чөтгөрийн хүчний учир хүмүүний ^бтэгш бус байдал ямар агууг бид харлаа.

14 Мөн тийн Их Эзэний “талбайнуудад хөдөлмөрлүүлэхээр хүмүүнийг шаргуу байдалд дуудах агуу дуудлагыг бид харлаа; мөн тийн харууслын хийгээд түүнчлэн баяслын хүмүүний дундах үхэл хийгээд устгалаас үүдэх харууслыг, түүнчлэн амьдралд хүргэх ^бХристийн гэрлээс үүдэх баяслыг агуу шалтгааныг — бид харлаа.

БҮЛЭГ 29

Алма тэнгэр элчийн урам зоригтойгоор наманчлалыг зарлахыг хүсэв—Их Эзэн бүх үндэстнүүдэд зориулан багш нарыг соёрхдог—Алма Их Эзэний ажлаар түүнчлэн Аммон болон түүний ах дүүсийн амжилтаар бахархав. Ойролцоогоор мээ 76 он.

Ай би тэнгэр элч болж, зүрхний минь хүсэл гүйцэлдэх болоосой, тиймээс би явж

8a Алма 27:16–19.

11a Алма 16:11.

б Алма 48:23;

С ба Г 42:45–46.

12a Алма 11:41.

13a 2 Ниф. 9:28.

б 1 Ниф. 17:35.

14a су Их Эзэний

талбай.

б су Гэрэл, Христийн гэрэл.

мөн Бурханы бүрээн дуугаар, газар дэлхийг сэгсрэх дуу хоолойгоор ярьж мөн хүмүүс болгонд наманчлалыг зарлаж болдог ч болоосой!

2 Тийм ээ, наманчлалыг мөн гэтэлгэлийн төлөвлөгөөг, газар дэлхийн бүхий л гадаргуу дээр дахин харамсал үгүй байж болохын тулд тэд наманчилж мөн Бурханд “ирэхийг бодгаль болгонд аянгын дуун мэт зарлах сан би.

3 Гэвч болгоогтун, би бол хүн, мөн энэ хүсэлдээ нүглийг үйлдлээ; учир нь Их Эзэн надад тохоосон зүйлүүдэд хангалуун байвал зохино би.

4 Шударга Бурханы чанд тогтоолыг би өөрийн хүслээр гуйвуулах ёсгүй, учир нь тэрээр тэдний “хүслийн дагуу, тэр нь үхэлд эсвэл амьдралд хүргэх байлаа ч түүнийг нь хүмүүнд зөвшөөрдгийг мэднэ би, тийм ээ, тэдний ^бтаалуудын дагуу, тэд авралд эсвээс устгалд хүргэх байлаа ч тэрээр хүмүүнд түүнийг нь оногдуулдаг, тийм ээ, өөрчлөгдөшгүй тэр тогтоолуудыг тэдэнд тохоодог.

5 Тийм ээ, мөн бүх хүмүүний өмнө сайн болон муу ирсэн байдгийг би мэднэ; муугаас сайныг ялгаж мэддэггүй тэр нь гэм зэмгүй; харин сайн хийгээд мууг ^амэддэг тэр, тэрээр сайн эсвээс мууг, амьдралыг эсвээс үхлийг, баяслыг

эсвээс ^бухамсрын гэмшлийг алийг нь ч хүслээ гэсэн түүний хүслийн дагуу тэр нь түүнд өгөгддөг бөлгөө.

6 Эдүгээ, би эдгээр зүйлийг мэддэг атал, өөрийнхөө дуудагдсан тэр ажлыг гүйцэтгэхээс илүүг би яагаад хүсэх болов?

7 Би тэнгэр элч байхыг, тиймээс дэлхийн бүх хязгаарт ч би ярьж чаддаг байхыг яагаад хүсэх болов, би?

8 Учир нь болгоогтун, Их Эзэн “бүх үндэстнүүдэд, өөрийн үгийг, тийм ээ, мэргэн ухаанаар, өөрийнхөө болно хэмээн ^бүзсэн бүгдийг заах заримыг тэдний өөрсдийнх нь үндэстэн хийгээд “хэлтнээс өгдөг болой; тиймийн тул Их Эзэн мэргэн ухаанд, шударга ёс хийгээд үнэний дагуу зөвлөдгийг бид харлаа.

9 Их Эзэний надад зарлигласныг би мэднэ, мөн үүгээр бахархана би. Би өөрөөрөө “бахархахгүй, харин Их Эзэн надад зарлигласан түүгээр бахархана би; тийм ээ, мөн энэ нь, зарим бодгалиудыг наманчлалд авчрахад Бурханы мутар дахь зэмсэг байж болох нь миний бахархал; мөн энэ нь миний баясал.

10 Мөн болгоогтун, ах дүүсийн маань олон нь үнэхээр гэмшихийг, мөн Их Эзэн Бурхандаа ирэхийг харахад, бодгаль минь баяслаар дүүр-

29 *а* Омни 1:26;
3 Ниф. 21:20.
4 *а* Дуул. 37:4.
б су Сонгох эрх.
5 *а* 2 Ниф. 2:18, 26;

Моро. 7:15–19.
су Ялган таних
бэлэг.
б су Ухамсар.
8 *а* 2 Ниф. 29:12.

б Алма 12:9–11.
в С ба Г 90:11.
9 *а* Алма 26:12.

нэм; тэгээд Их Эзэн миний төлөө “юу хийснийг санадаг би, тийм ээ, бүр тэрээр залбирлыг минь сонссоныг; тийм ээ, тэгээд миний зүг сунгасан түүний нигүүлсэнгүй мутрыг санадаг болой би.

11 Тийм ээ, мөн түүнчлэн эцэг өвгөдийнхөө боолчлогдож байсныг би санадаг; учир нь “Их Эзэн тэднийг боолчлолоос чөлөөлж, мөн тэгснээр өөрийн сүмийг байгуулсныг лавтай мэддэг болой би; тийм ээ, Их Эзэн Бурхан, Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан, мөн Иаковын Бурхан тэднийг боолчлолоос чөлөөлсөн билээ.

12 Тийм ээ, эцэг өвгөдийнхөө боолчлогдсоныг үргэлж санасаар байдаг би; мөн тэднийг египетчүүдийн гараас “чөлөөлсөн тэрхүү Бурхан тэднийг боолчлолоос чөлөөлсөн билээ.

13 Тийм ээ, мөнхүү тэр Бурхан тэдний дунд өөрийн сүмийг байгуулсан билээ; тийм ээ, мөнхүү тэр Бурхан намайг, энэ хүмүүст үгийг номлох ариун дуудлагаар дуудсан юм, мөн тэрэндээ “баясал минь дүүрэх их амжилтыг надад өгсөн билээ.

14 Гэвч би зөвхөн өөрийн амжилтанд баясах бус, харин Нифайн нутагт байсан ах дүүсийнхээ “амжилтын төлөө баясал минь илүү дүүрэн байна.

15 Болгоогтун, тэд үлэмж их хөдөлмөрлөсөн, мөн их

үр шимийг авчирсан; мөн шагнал нь хичнээн агуу байх билээ!

16 Эдүгээ, эдгээр ах дүүсийнхээ амжилтын тухай намайг бодоход сүнс минь зөөгдөн одож, бүр биеэс салах лугаа адил, баясал минь тийм агуу байна.

17 Мөн эдүгээ эдэнд, ах дүүст маань, тэд Бурханы хаант улсад сууж болно хэмээн Бурхан соёрхох болтугай; тийм ээ, мөн түүнчлэн тэдний хөдөлмөрийн үр шим болох тэдгээр нь бүгд дахин хэзээ ч алга болохгүй, харин түүнийг үүрд магтах болтугай. Мөн энэ нь миний үгсийн дагуу бүр ярьсны минь адилаар байхыг Бурхан соёрхох болтугай. Амен.

БҮЛЭГ 30

Христийг эсэргүүцэгч Корихор, Христийг, Цагаатгалыг, мөн бошиглолын суу билгийг дооглов— Тэрээр Бурхан байхгүй, хүний уналт гэж үгүй, нуглийн шийтгэл гэж үгүй, мөн Христ гэж үгүй хэмээн заав— Христ ирэх болно мөн бүх зүйл Бурхан байдгийг үзүүлдэг хэмээн Алма гэрчлэв— Корихор тэмдэг шаардаж, мөн цочирдон хэлгүй болгогдов— Чөтгөр тэнгэр элч мэтээр Корихорт үзэгдэж мөн юу хэлэхийг нь түүнд заасан ажээ— Корихор гишгэгдэн мөн үхэв. Ойролцоогоор мээ 76–74 он.

Болгоогтун, эдүгээ улиран

тохиох дор “Аммоны хүмүүс Жершоны нутагт суурьшуулагдсаны дараа, тийм ээ, мөн түүнчлэн леменчүүд уг нутгаас ^бтуугдсаны, мөн тэдний үхэгсэд нутгийн хүмүүсээр оршуулагдсаны дараа —

2 Эдүгээ тэдний үхэгсэд тоологдоогүйн учир нь тооны нь агуу ихээс болой; бас нифайчуудын үхэгсэд нь ч тоологдсонгүй — гэвч улиран тохиох дор тэд үхэгсдээ оршуулсны дараа, мөн түүнчлэн мацаг барилт мөн гашуудал, мөн залбирлын өдрүүдийн дараа (энэ нь Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арванзургадугаар он байв) бүх нутаг даяар үргэлжийн амгалан эхлэв.

3 Тийм ээ, мөн хүмүүс Их Эзэний зарлигуудыг дагахаар мэрийцгээсэн болой; мөн тэд Мосегийн хуулийн дагуу Бурханы “эслолуудыг гүйцэтгэхдээ чанд байв; учир нь тэд биелэгдэх хүртэл нь Мосегийн хуулийг ^бсахихаар сургагдав.

4 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арван зургадугаар оны турш хүмүүст ямар ч үймээн үгүй байв.

5 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын арван долдугаар оны эхлэлд үргэлжийн амгалан байв.

6 Гэвч улиран тохиох дор

арван долдугаар оны төгсгөлд, Зарахемлагийн нутагт нэгэн хүн ирэв, мөн тэр нь “Христийг эсэргүүцэгч байв, учир нь тэрээр Христийн ирэлтийн талаар бошиглогчдоор яригдсан бошиглолуудын эсрэг хүмүүст номлож эхлэв.

7 Эдүгээ хүмүүний “сүсэг бишрэлийн эсрэг хууль байсангүй; учир нь хүмүүсийг тэгш бус байдалд хүргэх хууль нь Бурханы зарлигуудын хувьд туйлын эсрэг байсны улмаас болой.

8 Учир нь сударт ийн өгүүлдэг: Та нар энэ өдөр хэнд үйлчлэхээ “сонго.

9 Эдүгээ хэрэв хүмүүн Бурханд үйлчлэхийг хүсвэл, энэ нь түүний эрх байв; эсвээс, хэрэв тэр Бурханд итгэдэг бол түүнд үйлчлэх нь түүний эрх байв; харин итгэдэггүй бол түүнийг шийтгэх хууль үгүй байв.

10 Харин хэрэв тэр аллага үйлдвэл тэрээр “үхлээр шийтгэгддэг байв; мөн хэрэв тэрээр дээрэмдсэн бол түүнчлэн шийтгэгддэг байв; мөн хэрэв тэр хулгайлсан бол тэрээр түүнчлэн шийтгэгддэг байв; мөн хэрэв тэр садар самууныг үйлдсэн бол тэрээр түүнчлэн шийтгэгддэг байв; тийм ээ, энэ бүх ёс бусын төлөө тэд шийтгэгддэг байв.

11 Учир нь хүмүүс гэмт хэргүүдийнхээ дагуу шүүгдэх

30 1a Алма 27:25–26.
су Антай-Нифай-
Лихайчууд.
б Алма 28:1–3.
3a су Мосегийн хууль.

б 2 Ниф. 25:24–27;
Алма 25:15.
6a су Христийн эсрэг.
7a Алма 1:17.
8a Иош. 24:15.

су Сонгох эрх.
10a су Ухлийн
Шийтгэл.

ёстой хэмээх нэгэн хууль байв. Гэсэн хэдий ч, хүмүүний сүсэг бишрэлийн эсрэг хууль байсангүй; тиймийн тул, хүмүүн нь зөвхөн үйлдсэн гэмт хэргүүдийнхээ улмаас шийтгэгддэг байв; тиймийн тул бүх хүмүүн “тэгш эрхтэй байв.

12 Мөн энэхүү Христийг эсэргүүцэгч, нэр нь Корихор гэгч тэр, (мөн хууль нь түүнд хүрч чадахгүй байв) Христ байх нь үгүй хэмээн хүмүүст номлож эхлэв. Мөн ийм маягаар тэр номлож, хэлрүүн:

13 Хоосон бөгөөд мунхаг найдвартаа хүлэгдсэн та нар, яагаад та нар өөрсдийгөө ийм мунхаг зүйлүүдээр буулгалдаг билээ? Яагаад та нар ямар нэгэн Христийг хүлээнэв? Учир нь нэг ч хүн ирэх түүний тухай юуг ч мэдэж чадахгүй.

14 Болгоогтун, та нарын бошиглолууд гэж нэрлэдэг эдгээр зүйлүүд, та нарын ариун бошиглогчдоор дамжуулагдсан гэж хэлдэг тэр нь, болгоогтун, тэдгээр нь эцэг өвгөдийн чинь мунхаг уламжлалууд болой.

15 Тэдгээрийн гарцаагүйг та нар яаж мэддэг вэ? Болгоогтун, та нар “харахгүй байгаа тэр зүйлийг мэдэж чадахгүй; тиймийн тул та нар хэн нэгэн Христ байх болно гэдгийг мэдэж чадахгүй.

16 Та нар урагш хараад мөн та нар нүглүүдийнхээ ангижралыг үздэг хэмээн хэлдэг.

Гэвч болгоогтун, энэ бол галзуурсан сэтгэлийн нөлөө; мөн та нарын энэ сэтгэцийн гажиг та нарыг тийм бус тэр зүйлүүдийн итгэлд хөтөлсөн эцэг өвгөдийн чинь уламжлалуудаас болдог.

17 Мөн тэрээр иймэрхүү олон зүйлийг тэдэнд хэлэв, хүмүүний нүглүүдийн төлөө цагаатгал хийгдэх боломжгүй, харин хүн бүр энэ амьдралд биеийг удирдахын дагуу аж төрдөг; тиймийн тул хүн бүр өөрийн суу билгийн дагуу дэгжиж, мөн хүн бүр өөрийн хүчний дагуу ялан дийлдэг; мөн хүмүүний хийсэн юу боловч гэмт хэрэг бус хэмээн тэдэнд өгүүлэв.

18 Мөн тийн тэрээр тэдэнд номлож, олны зүрх сэтгэлийг дагуулан удирдаж, тэднийг ёс бусдаа толгойгоо өргөхөд хүргэв, тийм ээ, олон эмэгтэйчүүдийг мөн түүнчлэн эрчүүдийг садар самууныг үйлдэхэд хүргэв—хүн үхэхэд түүний төгсгөл нь тэр хэмээн тэдэнд хэлж байв.

19 Эдүгээ энэ хүн түүнчлэн Жершоны нутагт нэгэнтээ леменчүүдийн хүмүүс асан Аммоны хүмүүсийн дунд эдгээр зүйлийг номлохоор очив.

20 Гэвч болгоогтун тэд нифайчуудын олноос илүү цэцэн байв; учир нь тэд түүнийг барьж, мөн түүнийг хүлж, мөн уг хүмүүсийн дээрх дээд санваартан асан Аммоны өмнө түүнийг авчрав.

21 Мөнхүү улиран тохиох дор тэрээр түүнийг уг нутгаас гаргуулав. Мөн тэрээр Гидеоны нутагт ирж, мөн түүнчлэн тэдэнд номлож эхлэв; мөн энд тэрээр их амжилттай байсангүй, учир нь тэрээр баривчлагдан мөн хүлэгдэж мөн дээд санваартны мөн түүнчлэн уг нутгийн дээрх ерөнхий шүүгчийн өмнө аваачигдав.

22 Мөнхүү улиран тохиох дор дээд санваартан түүнд хэлэв: Та яагаад Их Эзэний замуудыг гажуудуулан явдаг билээ? Та яагаад энэ хүмүүст, тэдний баяслыг сарниулахаар Христ гэж үгүй хэмээн заадаг билээ? Та яагаад ариун бошиглогчдын бүх бошиглолын эсрэг ярьдаг билээ?

23 Эдүгээ уг дээд санваартны нэр нь Гиддона байв. Мөн Корихор түүнд хэлэв: Би танай эцэг өвгөдийн мунхаг уламжлалуудыг заадаггүй учир, мөн тэдний дээр хүч мөн эрх мэдлийг эзэрхийлэхээр, тэднийг харанхуй бүдүүлэг байдалд байлгахаар, тэд толгойгоо эс өргөн, харин таны үгсийн дагуу дагуулагдаж болохын тулд зөнөг санваартнуудаар тогтоогдсон тэр мунхаг ёслол мөн зан үйлүүдийн дор өөрсдийгөө хүлэхийг энэ хүмүүст би заадаггүйн учир болой.

24 Та нар энэ хүмүүсийг чөлөөт хүмүүс хэмээн хэлдэг. Болгоогтун, тэднийг дарангуйлалд байна гэж би хэлнэ.

Та нар эртний бошиглолууд үнэн хэмээн хэлдэг. Болгоогтун, та нар тэдгээрийн үнэнийг мэдэхгүй хэмээн би хэлнэ.

25 Та нар энэ хүмүүсийг эх эцгийнхээ зөрчлийн учир, гэмт мөн унасан хүмүүс хэмээн хэлдэг. Болгоогтун, эх эцгийнхээ улмаас хүүхэд нь гэмтэй байдаггүйг би хэлнэ.

26 Мөн та нар түүнчлэн Христ ирэх болно хэмээн хэлдэг. Гэвч болгоогтун, Христ байдгийг та нар мэдэхгүй хэмээн би хэлнэ. Мөн та нар түүнчлэн тэрээр “дэлхийн нүглүүдийн төлөө егүүтгэгдэх болно гэж хэлдэг —

27 Мөн тийн та нар, эцэг өвгөдийнхөө мунхаг уламжлалаар, мөн өөрсдийн хүслийн дагуу энэ хүмүүсийг зайцуулан удирддаг; мөн та нар өөрсдийгөө тэдний гарын хөдөлмөрөөр хөрөнгөжүүлэхийн тулд, мөн тэд өөрсдийн эрх хийгээд боломжууддаа баясаж зүрхлэхгүй байлгахын тулд, мөн тэднийг зоригтойгоор дээш харж зүрхлэхгүй байлгахын тулд та нар тэднийг бүр дарангуйлалд байгаа мэтээр дорд байлгадаг.

28 Тийм ээ, тэднийг өөрсдийн хүслийн дагуу буулганд зүтгүүлэх, өөрсдийн уламжлалууд мөн өөрсдийн зүүд хийгээд өөрсдийн дур хүсэл хийгээд өөрсдийн үзэгдэл мөн өөрсдийн нууцууд гэгчээрээ тэднийг, хэрэв тэд өөрсдийнх нь үгсийн дагуу

үл үйлдвээс тэдний Бурхан гэж хэлэх, үл мэдэгдэх биеийг гомдооно хэмээн итгэхэд хүргэсэн санваартнуудаа гомдоох вий хэмээн тэд өөрсдийнхөө юмыг ашиглаж эс зүрхэлдэг — хэзээ ч харагдаагүй эсвээс мэдэгдээгүй, хэзээ ч байгаагүй эсвээс бас байдаггүй тэрхүү биеийг бөлгөө.

29 Эдүгээ дээд санваартан мөн ерөнхий шүүгч, түүний зүрх сэтгэлийн хатууг хараад, тийм ээ, тэд түүнийг бүр Бурханыг эсэргүүцэхийг нь хараад, тэд түүний үгсэд ямар ч хариу өгсөнгүй; харин тэд түүнийг хүлүүлж; мөн тэд түүнийг түшмэдийн гарт хүргэж, мөн түүнийг бүх нутгийн дээрх засаглагч асан ерөнхий шүүгч болон Алмагийн өмнө аваачиж болохын тулд, түүнийг Зарахемлагийн нутаг тийш илгээв.

30 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Алма болон ерөнхий шүүгчийн өмнө авчрагдаад тэрээр Гидеоны нутагт аашилсныхаа адилаар аашилж эхлэв; тийм ээ, тэрээр “Бурханыг доромжлов.

31 Мөн тэрээр Алмагийн өмнө “дуу хадаан ярив, мөн санваартнууд болон багш нарыг эсэргүүцэн доромжилж, хүмүүсийн хөдөлмөрөөр хөрөнгөжүүлэгдэх гэсэн шалтгааны учир хүмүүсийг эцэг өвгөдийнхөө хөгийн уламжлалуудад удирддаг хэмээн тэднийг буруутгаж байв.

32 Эдүгээ Алма түүнд хэлэв:

Бид өөрсдийгөө энэ хүмүүсийн хөдөлмөрөөр хөрөнгөжүүлээгүйг та мэднэ; учир нь болгоогтун би бүр шүүгчдийн засаглалын эхлэлээс одоог хүртэл Бурханы үгийг өөрийн хүмүүст тунхаглахаар нутгийг тойрч олон аялдаг хэдий ч өөрийгөө тэтгэхийн тулд би өөрийнхөө гараар хөдөлмөрлөдөг бөлгөө.

33 Мөн сүмд гүйцэтгэсэн олон хөдөлмөр надад буй хэдий ч, би хэзээ ч өөрийнхөө хөдөлмөрт бүр нэг “синаны дайтайг ч хүлээн авч байгаагүй; бас миний ах дүүс шүүхийн суудалд байснаас бусдаар бол тэгж байгаагүй; мөн тэгээд бид зөвхөн ажилласан цагаараа хуулийн дагуу хөлс авч байсан билээ.

34 Мөн эдүгээ, хэрэв бид сүм дэх өөрсдийн хөдөлмөрийн төлөө юу ч хүлээн авдаггүй болохоор, сүмд хөдөлмөрлөхөд бидэнд өөрсдөө ах дүүсийнхээ “баясалд баярлаж болохын тулд үнэнийг тунхаглахаас өөр ямар ашиг бидэнд буй билээ?

35 Тэгвэл биднийг өргөл хураахын тулд энэ хүмүүст номлодог хэмээн, бид өргөл барьц авдаггүйг мэдсээр байж та яагаад өөрөө ийн хэлж байна вэ? Мөн эдүгээ, тэдний зүрх сэтгэлд ийм баясал төрүүлдэг түүгээр энэ хүмүүсийг хуурч мэхэлдэг хэмээн та итгэдэг үү?

36 Мөн Корихор түүнд, Тийм гэж хариулав.

37 Мөн тэгэхэд Алма түүнд хэлэв: Та Бурхан байдагт итгэдэг үү?

38 Мөн тэрээр Үгүй гэж хариулав.

39 Эдүгээ Алма түүнд хэлэв: Та Бурхан байдгийг дахин үгүйсгэлээ, мөн түүнчлэн Христийг үгүйсгэх үү? Учир нь болгоогтун, би танд хэлнэ, Бурхан байдгийг, мөн түүнчлэн Христ ирэх болно гэдгийг би мэднэ.

40 Мөн эдүгээ “Бурхан байдаггүй, эсвээс Христ ирэхгүй гэсэн ямар нотолгоо танд байна? Зөвхөн таны үгнээс өөр, танд юу ч үгүйг би танд хэлнэ.

41 Гэвч болгоогтун, эдгээр зүйл үнэн гэсэн “гэрчлэл болж надад бүх зүйл байдаг; мөн түүнчлэн танд ч тэдгээр нь үнэн хэмээн өөрт чинь гэрчлэл болох бүх зүйл байгаа; мөн та тэднийг үгүйсгэх үү? Эдгээр зүйл үнэн гэдэгт та итгэдэг үү?

42 Болгоогтун, таны итгэдгийг би мэднэ, гэвч та худалч сүнсэнд эзэмдүүлэгдэж, мөн таны дотор зай эзлэхгүй байж болохын тулд Бурханы Сүнсийг та холдуулжээ; харин чөтгөр таныг захирах хүчийг агуулдаг, мөн тэр Бурханы хүүхдүүдийг устгаж болохын тулд зальт төлөвлөгөөгөө гүйцэтгэн таныг дагуулж явдаг бөлгөө.

43 Мөн эдүгээ Корихор

Алмад хэлэв: Хэрэв та надад би Бурхан байдагт үнэмшүүлэгдэж болохын тулд “тэмдгийг, тийм ээ, надад тэрээр хүчтэй гэдгийг үзүүлэх аваас, мөн тэгвэл би таны үгсийн үнэнд үнэмшүүлэгдэх болно.

44 Гэвч Алма түүнд хэлэв: Танд хангалттай тэмдгүүд байсан; та Бурханаа сорих гэж үү? Танд эдгээр “бүх ах дүүсийн чинь, мөн түүнчлэн бүх ариун бошиглогчдын гэрчлэл байхад, надад тэмдэг үзүүл хэмээн хэлэх гэж үү? Судрууд таны өмнө дэлгээстэй байна, тийм ээ, мөн ⁶бүх зүйл Бурхан байдгийг үзүүлдэг; тийм ээ, бүр ^агазар дэлхий, мөн үүний гадаргуу дээрх бүх зүйл, тийм ээ, мөн үүний ^хөдөлгөөн, тийм ээ, мөн түүнчлэн өөрсдийн байнгын замаар хөдлөх тэр бүх ^ггарагууд Эрхэм дээд Бүтээгч байдгийг гэрчилдэг юм.

45 Мөн та тийм хэдий ч, энэ хүмүүсийн зүрх сэтгэлийг зайцуулан удирдаж, Бурхан байдаггүйг тэдэнд гэрчилсээр явах уу? Мөн та эдгээр бүх гэрчүүдийн эсрэг үгүйсгэсээр л байх уу? Мөн тэрээр хэлэв: Тийм ээ, надад тэмдэг үзүүлэхгүй аваас би үгүйсгэх болно.

46 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма түүнд хэлэв: Болгоогтун, таны зүрх сэтгэл хатуугийн учир, тийм ээ, таны бодгаль устгагдаж болохын

40a Дуул. 14:1.

41a су Гэрч.

43a Иаков 7:13–21;

С ба Г 46:8–9.

су Тэмдэг.

44a Мозая 13:33–34.

б Дуул. 19:1;

С ба Г 88:47.

в Иов 12:7–10.

г Хил. 12:11–15.

д Мосе 6:63.

тул, та үнэний сүнсийг эсэргүүцсээр байна хэмээн га шууднам би.

47 Гэвч болгоогтун, бодгаль тань алдагдах нь, та өөрийн худал хийгээд зусар үгсээрээ олон бодгалийг устгал уруу аваачих арга байснаас “илүү дээр билээ; тиймийн тул хэрэв та дахин үгүйсгэвэл, болгоогтун та хэлгүй болж, та дахин хэзээ ч амаа нээж чадахгүй, та дахин энэ хүмүүсийг мэхлэхгүйн тулд Бурхан таныг цохих болно.

48 Эдүгээ Корихор түүнд хэлэв: Би Бурхан оршдогийг үгүйсгэхгүй, гэвч би Бурхан байдагт итгэдэггүй; мөн түүнчлэн та нар Бурхан байдгийг мэдэхгүй хэмээн би хэлнэ; мөн та нар надад тэмдэг үзүүлэхгүй бол, би итгэхгүй.

49 Эдүгээ Алма түүнд хэлэв: Үүнийг би тэмдэг болгон танд өгөх болно, та миний үгсийн дагуу “цочирдон хэлгүй болгогдох болно; мөн би Бурханы нэрээр, та дахин дуугарахгүй болохын тулд хэлгүй байх болно хэмээн хэлнэ.

50 Эдүгээ Алма эдгээр үгийг хэлэхэд, Корихор Алмагийн үгсийн дагуу дуугарч чадахгүй, хэлгүй болгогдов.

51 Мөн эдүгээ ерөнхий шүүгч үүнийг хараад, тэрээр гараа сунган мөн Корихорт бичиж, өгүүлсэн нь: Та Бурханы хүчинд үнэмшүүлэгдэв үү? Алма өөрийн тэмдгийг

хэний дээр үзүүлээсэй хэмээн та хүссэн билээ? Тэрээр танд тэмдэг үзүүлэхийн тулд бусдыг зовоохыг та хүсэв үү? Болгоогтун, тэрээр танд тэмдэг үзүүлээ; мөн эдүгээ та дахин маргах уу?

52 Мөн Корихор гараа сунгаж мөн бичиж, өгүүлсэн нь: Би хэлгүй гэдгээ мэднэ, учир нь би ярьж чадахгүй байна; мөн би Бурханы хүчээс өөр юу ч үүнийг миний дээр авчирч чадахгүйг мэднэ; тийм ээ, мөн би Бурхан байдгийг ямагт “мэддэг байсан.

53 Гэвч болгоогтун, чөтгөр намайг “мэхэлжээ; учир нь тэрээр надад тэнгэр элчийн дүрээр ‘үзэгдэж, мөн надад: явагтун мөн энэ хүмүүсийг буцаан тат, учир нь тэд бүгд үл мэдэгдэх Бурханы хойноос төөрөлдөн одов хэмээн хэлсэн билээ. Мөн тэрээр надад хэлсэн нь: “Бурхан гэж үгүй; тийм ээ, мөн тэрээр миний хэлэх ёстойг заасан. Мөн би түүний үгсийг заасан; мөн тэдгээр нь ‘эгэл оюунд таалагдах байсан учир би тэдэнд заасан; мөн би тэдгээрийг, бүр их амжилтанд хүртлээ заасан, үүний хэрээр би тэдгээр нь үнэхээр үнэн гэдэгт итгэсэн билээ; мөн үүний учир би үнэнийг, бүр өөр дээрээ энэ их зүхлийг авчрах хүртлээ сөрөн зогссон бөлгөө.

54 Эдүгээ тэр үүнийг хэлээд, тэрээр уг зүхэл түүнээс

47a 1 Ниф. 4:13.

49a II аст. дэд 13:20.

52a Алма 30:42.

53a Иаков 7:14.

б 2 Кор. 11:14;

2 Ниф. 9:9.

в Дуул. 10:4.

г су Тачаангуй, Зуурдын.

авагдаж болохын тулд, Бурханд залбирахыг Алмагаас гуйв.

55 Гэвч Алма түүнд хэлэв: Хэрэв энэ зүхэл танаас авагдах юм бол та дахин энэ хүмүүсийн зүрх сэтгэлийг зайцуулан удирдана; тиймийн тул, энэ нь танд бүр Их Эзэний тааллын дагуу байх болно.

56 Мөнхүү улиран тохиох дор уг зүхэл Корихороос авагдсангүй; харин тэр зайлуулагдаж, мөн хоолоо олохын тулд байрнаас байранд гуйлга гуйн явах болжээ.

57 Эдүгээ Корихорт юу тохиолдсон тухай мэдээ тэр даруй бүх нутаг даяар зарлагдав; тийм ээ, Корихорын үгсэд итгэсэн тэд даруй наманчлах ёстой, үгүй бол нэгэн адил шүүлт тэдний дээр ирнэ хэмээх зар ерөнхий шүүгчээр уг нутаг дахь бүх хүмүүст илгээгдсэн байв.

58 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгд Корихорын ёс бусад үнэмшүүлэгдсэн байв; тиймийн тул тэд бүгд дахин Их Эзэнд хөрвүүлэгдэв; мөн энэ нь Корихорын маягийг дагах алдсуудыг эцэс болгов. Мөн Корихор байрнаас байр хэсч, өөрийгөө тэтгэх хүнс гуйж явсан болой.

59 Мөнхүү улиран тохиох дор тэр хүмүүсийн дунд орохдоо, тийм ээ, өөрсдийгөө нифайчуудаас тусгаарлан мөн зорамчууд гэж өөрсдийгөө

нэрлэсэн, Зорам гэгч нэртэй түүгээр удирдуулж асан хүмүүсийн дунд—мөн тэрээр тэдний дунд одох үед, болгоогтун, бүр үхэх хүртлээ тэрээр нухчигдан мөн дэвслэгдэв.

60 Мөн тийн Их Эзэний замуудыг гажуудуулагч түүний төгсгөлийг бид харав; мөн тийн “чөтгөр эцсийн өдөр өөрийн хүүхдийг эс^бдэмждэгийг, харин тэднийг яаран “там уруу чирэдгийг бид харав.

БҮЛЭГ 31

Урвагч зорамчуудыг буцаан залруулах номлолыг Алма толгойлов — Зорамчууд Христийг үгүйсгэж, нэгэн хэвийн залбирлуудаар сүсэглэн, мөн сонгогдсон хэмээх буруу ойлголтууддаа итгэв — Номлогчид Ариун Сүнсээр дүүргэгдэв — Тэдний зовлонгууд Христийн баясалд автагдав. Ойролцоогоор мээ 74 он.

Эдүгээ улиран тохиох дор Корихорын төгсгөлийн дараа, зорамчууд Их Эзэний замуудыг гажуудуулж байна, мөн тэдний удирдагч Зорам хүмүүсийн зүрх сэтгэлийг амьгүй “шүтээнүүдэд^б бөхийхөд удирдаж байна гэсэн мэдээг Алма хүлээн авч, түүний зүрх сэтгэл уг хүмүүсийн алдсуудын учир дахин “шаналж эхлэв.

2 Учир нь өөрийн хүмүүсийн дундах алдсуудыг мэдсэн нь

60a су Чөтгөр.

б Алма 3:26–27; 5:41–42;
С ба Г 29:45.

в су Там.

31 1a 2 Ниф. 9:37.
су Хиймэл шүтээн.

б Ег. 20:5; Мозая 13:13.

в Алма 35:15.

Алмад их “гуниг харамслыг төрүүлэв; тиймийн тул зорамчууд нифайчуудаас тусгаарласны учир түүний зүрх сэтгэл үлэмж хямрав.

3 Эдүгээ зорамчууд өөрсдөө Зарахемла нутгийн дорнод дахь, тэнгисийн эрэгт ойрхноор хиллэж байсан, Жершоно нутгийн өмнөдөд байсан, түүнчлэн өмнөд талаараа леменчүүдээр дүүрэн байх тэр аглаг буйдтай хиллэсэн Антионум гэж нэрлэсэн нутагтаа нэгдэн цугларцгаасан байв.

4 Эдүгээ нифайчууд, зорамчууд леменчүүдтэй харилцаанд орох вий хэмээн, мөн энэ нь нифайчуудын талд агуу алдагдлын шалтгаан болох вий хэмээн ихээр айв.

5 Мөн эдүгээ, шударга байсан түүнийг хийхэд хүмүүсийг “удирдахад ^бүгийг “номлох нь их нөлөө болж байсан учир — тийм ээ, энэ нь хүмүүсийн оюун ухаанд илднээс, эсвээс тэдэнд тохиолдсон юунаас ч илүү хүчтэйгээр нөлөө үзүүлж байв — тиймийн тул тэд Бурханы үгийн нөлөөлөх хүчийг сорих нь зайлшгүй болов хэмээн Алма боджээ.

6 Тиймийн тул тэрээр Аммон, мөн Аарон, мөн Омне-рыг авч; мөн тэрээр Химнайг Зарахемла дахь сүмд орхиж; харин дээрх гурвыг тэрээр

өөртэйгөө авчээ түүнчлэн Мелект байсан Амулек мөн Зиезромыг; мөн түүнчлэн тэрээр хөвгүүдийнхээ хоёрыг нь авав.

7 Эдүгээ тэрээр хөвгүүдийнхээ ахмадыг нь өөртэйгөө авсангүй, мөн түүний нэр “Хиламан байв; харин тэрээр өөртэйгөө авсан тэдний нэрс нь Шиблон мөн Кориантон нар байв; мөн эдгээр нь түүнтэй хамт ^бзорамчуудын дунд тэдэнд үгийг номлохоор одсон тэдний нэрс бөлгөө.

8 Эдүгээ зорамчууд бол нифайчуудаас “тэрслэгчид байв; тиймийн тул Бурханы үг тэдэнд номлогдсон ажээ.

9 Гэвч тэд их төөрөгдлүүдэд “унасан байв, учир нь тэд Бурханы зарлигууд хийгээд түүний тогтоолуудыг Мосегийн хуулийн дагуу дагахыг чармайсангүй бөлгөө.

10 Бас тэд уруу таталтанд орохгүй байж болохын тулд, Бурханд хандан өдөр бүрийн залбирал болоод гуйлтаа үргэлжлүүлэх гэсэн тэр сүмийн үйлүүдийг тэд анхааран үзсэнгүй билээ.

11 Тийм ээ, эцсийн дүнд, тэд маш олон тохиолдолд Их Эзэний замуудыг гажуудуулж байв; тиймийн тул, энэ шалтгааны учир, Алма болон түүний ах дүүс уг нутагт тэдэнд үгийг номлохоор одов.

12 Эдүгээ, тэд уг нутагт

2а Мозая 28:3;
3 Ниф. 17:14;
Мосе 7:41.
5а Жером 1:11–12;
С ба Г 11:2.

б Евр. 4:12; Иаков 2:8;
Алма 36:26.
в Инос 1:23;
Алма 4:19.
су Номлох.

7а су Хиламан,
Алмагийн хүү.
б Алма 30:59.
8а Алма 24:30.
9а су Урвалт.

ирсний дараа, болгоогтун, тэдний гайхлыг төрүүлсэн нь зорамчууд синагогууд барьсан явдал байв, мөн тэд Их Эзэний өдөр гэж нэрлэсэн долоо хоногийн нэг өдөр өөрсдөө нэгдэн цуглардаг байв; мөн тэд Алма болон түүний ах дүүсийн хэзээ ч хараагүй тийм маягаар сүсэглэдэг болохыг тэд олж мэдэв.

13 Тухайлбал тэд синагогийнхаа төвд толгойноос өндөрт өргөгдсөн, дээр нь зогсох индэр барьсан байлаа; мөн түүний дээр зөвхөн нэг хүн багтах ажээ.

14 Тиймийн тул, “шүтэн сүсэглэхийг хүссэн хэн боловч явж мөн үүний орой дээр нь зогсоод, мөн тэнгэрийн зүг гараа сунган, мөн чанга дуугаар:

15 Ариун, ариун Бурхан; та бол Бурхан, мөн та бол ариун гэдэгт бид итгэдэг, мөн та сүнс байсан, мөн та бол сүнс, та үүрд сүнс байх болно гэдэгт бид итгэдэг гэж хэлэн хашгирах ёстой аж.

16 Ариун Бурхан, та биднийг ах дүүсээс маань салгасан гэдэгт бид итгэдэг; мөн тэдний эцэг өвгөдийн гэнэн тэнэгээр тэдэнд гардуулагдсан ах дүүсийнхээ уламжлалуудад бид итгэдэггүй; харин та биднийг өөрийн “ариун хүүхдүүд байхаар”⁶ сонгосон гэдэгт бид итгэдэг; мөн түүнчлэн Христ гэж үгүй байх болно гэдгийг та бидэнд мэдүүлж өгсөн билээ.

17 Гэвч та бол өчигдөр, өнөөдөр, мөн үүрд нэгэн адил; мөн та биднийг аврагдахаар “сонгосон, харин бидний эргэн тойронд байгаа бүгдийг өөрийн хилэнгээр доош тамд хаягдахаар сонгосон билээ; учир нь уг ариун чанарт тань, Ай Бурхан, бид танд талархдаг; мөн түүнчлэн тэдний сэтгэлийг танаас холдуулж төөрөгдүүлэн удирдах, Христэд итгэх итгэлд доош хүлэх тэр, ах дүүсийн маань мунхаг уламжлалуудыг бид дагахгүй байж болохын тулд биднийг сонгосонд тань бид талархдаг, Бурхан минь.

18 Мөн үүнчлэн бид сонгогдсон мөн ариун хүмүүс учраас бид танд талархдаг, Ай Бурхан минь. Амен.

19 Эдүгээ улиран тохиох дор Алма болон түүний ах дүүс мөн түүний хөвгүүд эдгээр залбирлыг дуулаад, тэд хэмжээлшгүйгээр цочирдон гайхав.

20 Учир нь болгоогтун, хүн бүр урагшилж мөн эдгээрийн нэгэн адил залбирлуудыг өргөж байв.

21 Эдүгээ уг газар тэднээр Рамеумптом, орчуулбал ариун тавцан хэмээн нэрлэгдсэн байв.

22 Эдүгээ, энэ тавцангаас тэд, хүн бүр, Бурханд хандсан адилхан залбирлаа, тэд түүгээр сонгогдсон хэмээн, мөн тэрээр тэднийг ах дүүсийнх нь уламжлалд эс удирдсан хэмээн, мөн тэдний өөрс-

дийнх нь зүрх сэтгэл огтхон ч мэдэхгүй ирэх зүйлүүдэд итгэхээр хулгайлагдаагүй хэмээн Бурхандаа талархлаа өргөж байв.

23 Эдүгээ, хүмүүс бүгд энэ маягаар талархал өргөснийхөө дараа, тэд гэртээ эргэж очоод, тэд өөрсдөө мөнөөх ариун индэрт өөрсдийн маягаар талархал өргөхөөр дахин цугларах хүртлээ Бурханыхаа тухай дахин “огт ярьдаггүй ажээ.

24 Эдүгээ Алма үүнийг хараад зүрх сэтгэл нь “гашуудав; учир нь тэрээр тэд ёс бус мөн гажууд хүмүүс байсныг үзэв; тийм ээ, тэрээр тэдний зүрх сэтгэл алтан дээр, мөн мөнгөн дээр, мөн бүх төрлийн сайн эд бараанууд дээр байрласныг харав.

25 Тийм ээ, мөн тэрээр түүнчлэн тэдний зүрх сэтгэл бардамналдаа агуу онгиргон занд “өргөгдсөнийг харав.

26 Мөн тэрээр дуугаа тэнгэрт өргөн, мөн “хашгирч, хэлрүүн: Ай хэр удаан, Ай Их Эзэн, та зарц нараа энэ доор бие махбодид, хүмүүний үрсийн дунд бузар ёс бусыг болгоохоор оршин байхыг тэвчих вэ?

27 Болгоогтун, Ай Бурхан, тэдний зүрх сэтгэл бардамналдаа автагдсан хэдий ч тэд танд “залбирна. Болгоогтун, Ай Бурхан, тэд дэлхийн дэмий хоосон зүйлүүдээр ихээр

“ихэмсэглэж байхдаа, амаараа танд залбирах ажгуу.

28 Болгоогтун, Ай Бурхан минь, тэдний үнэт хувцас, мөн тэдний бөгжнүүд, мөн тэдний “бугуйвчнууд, мөн тэдний алтан чимгүүд, мөн тэдний өөрсдийгөө гоёсон бүх үнэт зүйлсийг; мөн болгоогтун, тэдний зүрх сэтгэл тэдгээрийн дээр байрлажээ, мөн гэсэн хэдий ч тэд танд залбирч ийн хэлнэ—Бид танд талархаж байна, Ай Бурхан, учир нь бусад нь мөхөх ёстой байхад, бид таны хувьд сонгогдсон хүмүүс.

29 Тийм ээ, мөн Христ гэж байхгүй байх болно гэдгийг та тэдэнд мэдүүлсэн хэмээн тэд хэлдэг.

30 Ай Их Эзэн Бурхан, энэ хүмүүсийн дунд ийм ёс бус хийгээд үнэнч бус байдлыг та хэр удаан тэвчих билээ? Ай Их Эзэн, өөрийн сул дорой байдалд тэвчээртэй хандах хүчийг та надад өгөөч. Учир нь би сул дорой, мөн энэ хүмүүсийн дундах ийм ёсон бус нь сэтгэлийг минь өвтгөх бөлгөө.

31 Ай Их Эзэн, зүрх сэтгэл минь үлэмж харамсана; та бодгалийг минь “Христээр тайтгаруулна уу. Ай Их Эзэн та энэ хүмүүсийн алдсын учир, дээр минь ирэх эдгээр зовлонг тэсвэртэйгээр тэвчиж болохын тул надад хүч байж болохыг соёрхоно уу.

23a Иаков 1:21–25.

24a Эхл. 6:5–6.

25a Иаков 2:13;

Алма 1:32.

26a Моце 7:41–58.

27a Иса. 29:13.

б су Бардамнал.

28a Иса. 3:16–24.

31a Иохан 16:33.

32 Ай Их Эзэн, бодгалийг минь та тайтгаруулж, мөн надад, мөн түүнчлэн надтай хамт буй миний хамтран ажиллагчдад ч нэгэн адил амжилтыг өгнө үү — тийм ээ, Аммон, мөн Аарон, мөн Омнер, мөн түүнчлэн Амюлек мөн Зиезром, мөн түүнчлэн “хоёр хөвгүүнд минь — тийм ээ, бүр эд бүгдийг та тайтгаруулна уу, Ай Их Эзэн, тийм ээ, та тэдний бодгалиудыг Христээр тайтгаруулаач.

33 Энэ хүмүүсийн алдсуудын учир тэдний дээр ирэх зовлонгуудыг гэвчиж болохын тулд; хүчтэй байж болохыг та тэдэнд соёрхоно уу.

34 Ай Их Эзэн, тэднийг дахин Христээр танд авчрахад амжилттай байхыг та “бидэнд соёрхоно уу.

35 Болгоогтун, Ай Их Эзэн, тэдний “бодгаль эрхэм үнэт, мөн тэдний олон нь бидний ах дүүс; тиймийн тул, бид тэднийг, ах дүүсээ дахин танд авчирч болохын тулд, Ай Их Эзэн, хүч чадал хийгээд мэргэн ухааныг бидэнд өгөөч.

36 Эдүгээ улиран тохиох дор Алма эдгээр үгийг хэлээд, өөртэйгөө хамт байсан тэд бүгдийн дээр “гараа ^бхавсрав. Мөн болгоогтун, тэрээр тэдний дээр гараа хавсрахад, тэд Ариун Сүнсээр дүүргэгдэв.

37 Мөн түүний дараа тэд юу идэх, эсвэл юу уух, эсвэл юу өмсөх билээ гэсэн өөрсдийгөө

хичээсэн “бодолгүйгээр тэд нэг нэгнээсээ салж одов.

38 Мөн Их Эзэн тэднийг өлсгөлгүйгээр бас цангаалгүйгээр хангаж байв; тийм ээ, мөн тэрээр түүнчлэн тэдэнд Христийн баясалд автагдаж байснаас бусдаар, өөр “зовлонгуудыг үзүүлэхгүйн тулд тэдэнд хүч чадал өгч байв. Эдүгээ энэ нь Алмагийн залбирлын дагуу байв; мөн энэ нь тэрээр ^битгэлтэйгээр залбирсны учир болой.

БҮЛЭГ 32

Зовлонгууд нь тэднийг даруу болгодог ядууст Алма заав—Итгэл нь үнэн боловч хараагүй тэрхүү зүйлд найдах найдлага юм—Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд мөн хүүхдүүдэд тэнгэр элчүүд тохинуулдгийг Алма гэрчлэв—Алма үгийг нэгэн үртэй зүйрлэв—Энэ нь суулгагдаж мөн арчлагдах ёстой—Тэгээд энэ нь мөнх амьдралын жимс нь түүгдэх мод болон ургадаг. Ойролцоогоор мээ 74 он.

Мөнхүү улиран тохиох дор тэд явж, мөн тэдний синагогуудад, мөн тэдний гэрт орж хүмүүст Бурханы үгийг номлож эхлэв; тийм ээ, мөн тэд бүр тэдний гудамжнуудад үгийг номлов.

2 Мөнхүү улиран тохиох дор тэдний дунд ихэд хөдөлмөрлөсний дараа, тэд хүмүүсийн

32a Алма 31:7.

34a 2 Ниф. 26:33.

35a су Хүн—Хүний үнэ цэнэ.

36a су Гар тавих.

б 3 Ниф. 18:36–37.

37a Мат. 6:25–34;

3 Ниф. 13:25–34.

38a Мат. 5:10–12;

Мозая 24:13–15;

Алма 33:23.

б су Итгэл.

“ядуу хэсгийн дунд амжилт олж эхлэв; учир нь болгоогтун, тэд хувцасныхаа муугийн учир синагогуудаас хөөгдсөн ажээ—

3 Тиймийн тул өөрсдийн синагогуудад Бурханыг шүтэхээр орох нь, бузар муугийн адил үнэлэгдсэний учир тэдэнд зөвшөөрөгдсөнгүй; тиймийн тул тэд ядуу байв; тийм ээ, тэд ах дүүсээрээ новш мэт үнэлэгддэг байв; тиймийн тул тэд дэлхийн зүйлүүдээр “ядуу байв; мөн түүнчлэн тэд зүрх сэтгэлдээ ч ядуу байв.

4 Эдүгээ, Алма Онида толгой дээр хүмүүст зааж мөн ярьж байхад, түүнд их олон ард ирэв, бидний тухайлан ярьж байсан, дэлхийн зүйлүүдээр ядуугийн учир, “зүрх сэтгэлдээ ядуу асан тэд байлаа.

5 Мөн тэд Алмад ирж; мөн тэдний дундаас түрүүнд нь байсан нэг нь түүнд хэлэв: Болгоогтун, миний эдгээр ах дүүс “юу хийх билээ, учир нь тэд ядуу зүдүүгийнхээ учир бүх хүмүүст, тийм ээ, мөн ялангуяа өөрсдийн санваартнуудаар ад үзэгддэг; учир нь, өөрсдийн гараар ихэд хөдөлмөрлөж барьсан синагогуудаас маань биднийг тэд ^бзайлуулав; мөн тэд бидний үлэмж ядуу зүдүүгийн учир зайлуулав; мөн бидэнд Бурханаа шүтэх газар

алга; мөн болгоогтун ^вбид юу хийх билээ?

6 Мөн эдүгээ Алма үүнийг дуулаад, тэрээр эргэн харж, тэрээр тэр даруй түүнтэй нүүр тулгарч, мөн тэрээр агуу баясалтайгаар болгоов; учир нь “зовлонгууд нь тэднийг үнэхээр ^вдаруу болгосныг, мөн тэд үгийг сонсоход ^вбэлтгэгдсэнийг тэрээр болгоов.

7 Тиймийн тул тэрээр нөгөө ардуудад дахин юу ч хэлсэнгүй; харин тэр гараа сунгаж, мөн үнэхээр гэмшсэн байдалтай байхыг нь харсан тэдэнд хашгирч, мөн тэдэнд хэлэв:

8 Та нар “зүрх сэтгэлдээ даруу болохыг би болгоож байна; мөн тийм бол адислагдсан болой та нар.

9 Болгоогтун, Бид юу хийх билээ?—учир нь бид Бурханаа шүтэж чадахгүй болон бид синагогуудаасаа зайлуулагдав хэмээн ах тань хэллээ.

10 Болгоогтун би та нарт хэлнэ, та нар зөвхөн өөрсдийн синагогуудад бус бол “Бурханыг шүтэж чадахгүй хэмээн бодно уу?

11 Мөн үүнээс гадна, та нар Бурханыг долоо хоногт зөвхөн нэг удаа шүтэх ёстой хэмээн бодно уу хэмээн би асууя?

12 Би та нарт хэлнэ, та нар даруухан байж болохын тулд, мөн та нар “мэргэн ухааныг сурч болохын тулд, та нар

32 *2a* су Ядуу.

3*a* Алма 34:40.

4*a* су Ядуу—Сүнсэндээ номхон долгөөн.

5*a* Сур. үгс 18:23.

б Алма 33:10.

в Үйлс 2:37–38.

б су Дайсан.

б су Даруу, Даруу байдал.

в Алма 16:16–17;

С ба Г 101:8.

8*a* Мат. 5:3–5.

10*a* су Шүтэн бишрэх.

12*a* Ном. үгс 4:13.

синагогуудаасаа хөөгдсөн нь сайн болой; учир нь та нар мэргэн ухаанд суралцах нь чухал юм; та нарын үлэмж ⁶ядуу зүдүүгийн учир ах дүүсээрээ та нар үзэн ядагдсан ажээ, та нар хөөгдсэн учир, та нар зүрх сэтгэлийн даруу байдалд авчрагдсан ажгуу; учир нь та нар даруу байдалд зайлшгүйгээр авчрагдсан болгоо.

13 Мөн эдүгээ, та нар даруу байхаар албадагдсан учир та нар адислагдсан болой; учир нь хүн заримдаа, хэрэв тэрээр даруу байхаар албадуулагдсан аваас, наманчлалыг эрэлхийлдэг; мөн эдүгээ наманчилсан хэн боловч нигүүлслийг олох нь гарцаагүй; мөн нигүүлслийг олсон хийгээд эцсийг хүртэл “тэвчих тэр нь аврагдах болно.

14 Мөн эдүгээ, та нар даруу байхаар албадуулагдсан учир та нар адислагдсан хэмээн би та нарт хэлсэн, үгийн учир өөрсдийгөө үнэхээр даруусгах тэд илүү ихээр адислагдсан хэмээн та нар бодохгүй байна уу?

15 Тийм ээ, өөрийгөө үнэхээр даруусгадаг, мөн нүглээ наманчилдаг, мөн эцсийг хүртэл тэвчих тэрээр, мөнхүү тэр нь адислагдах болно— тийм ээ, өөрсдийн үлэмж ядуу зүдүүгийнхээ учир даруу байхаар албадагдсан тэднээс бүр илүү ихээр адислагдсан болой.

16 Тиймийн тул, даруу байхыг албадуулалгүйгээр өөрсдийгөө “даруу болгох тэд адислагдсан болой; эсвээс, өөрөөр хэлбэл, Бурханы үгэнд итгэх, мөн зүрх сэтгэлийн зөрүүдгүйгээр баптисм хүртэх, тийм ээ, итгэхээсээ өмнө үгийг мэдэхээр хүргэгдэлгүйгээр, өөрөөр хэлбэл мэдэхээр албадуулаагүй тэр нь адислагдсан болой.

17 Тийм ээ, хэрэв та бидэнд тэнгэрээс “тэмдэг үзүүлбэл, тэгвэл бид гарцаагүй мэдэх болно; тэгвэл бид итгэх болно хэмээн хэлэх тэд олон байдаг.

18 Эдүгээ би асууя, энэ нь итгэл гэж үү? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй; учир нь хэрэв хүн аливаа зүйлийг мэддэг аваас “итгэх шалтгаангүй, учир нь тэр үүнийг мэддэг.

19 Мөн эдүгээ, Бурханы тааллыг “мэддэг мөн үл хийгч тэрээр, итгэх эсвээс зөвхөн итгэх шалтгаан бүхий мөн зөрчилд унадаг түүнээс хичнээн илүүгээр зүхэгдсэн билээ?

20 Эдүгээ энэ зүйлийн талаар та нар цэгнэх ёстой. Болгоогтун, би та нарт хэлнэ, энэ нь нэг гар дээр байгаа шиг бүр нөгөө дээр нь ч буй; мөн энэ нь хүн бүрд өөрийн нь үйлийн дагуу байх болно.

21 Мөн эдүгээ миний итгэлийн талаар хэлсэнчлэн— “итгэл бол юмсын тухай төгс

12᠖ Сур. үгс 16:8.

13а Алма 38:2.

16а су Даруу, Даруу

байдал.

17а су Тэмдэг.

18а Ифер 12:12, 18.

19а Иохан 15:22–24.

21а Иохан 20:29; Евр. 11.

мэдлэгтэй байх нь бус юм; тиймийн тул хэрэв та нар итгэлтэй аваас та нар үнэн хийгээд ⁶үл харагдах зүйлүүдэд ^анайдах болно.

22 Мөн эдүгээ, болгоогтун, Бурхан бол түүний нэрэнд итгэдэг бүгдэд нигүүлсэнгүйг би та нарт хэлнэ, мөн та нарыг санаасай хэмээнэ би; тиймийн тул тэрээр юун түрүүнд, та нарыг, тийм ээ, бүр түүний үгсэд итгээсэй хэмээн хүсдэг.

23 Мөн эдүгээ, тэрээр өөрийн үгийг тэнгэр элчүүдээр эрчүүдэд, тийм ээ, “зөвхөн эрчүүдэд бус харин түүнчлэн эмэгтэйчүүдэд мэдүүлдэг. Эдүгээ энэ нь бүгд бус; бяцхан ⁶хүүхдүүдэд ч мэргэнийг мөн эрдэмтнийг ичээх үгс олон удаа тэдэнд өгөгдсөн байдаг.

24 Мөн эдүгээ, хайрт ах дүүс минь, та нар зовж мөн хөөгдсөн учир та нар юу хийхээ надаас мэдэхийг хүссэн учир—эдүгээ би зөвхөн үнэн байдлын дагуу та нарыг шүүнэ хэмээн та нарыг бодоосой гэж хүсэхгүй байна би—

25 Учир нь та нар бүгд өөрсдөө даруу байхаар албадуулагдсан гэсэнгүй би; учир нь ямар ч нөхцөл байдалд байсан өөрсдийгөө даруу болгох зарим нь та нарын дунд байгаа гэдэгт би үнэхээр итгэж байна.

26 Эдүгээ, итгэлийн талаар миний хэлсэнчлэн—энэ нь төгс мэдлэг биш—үүнчлэн энэ нь миний үгсийн хувьд тийм буй. Итгэл нь төгс мэдлэг бусын адил та нар эхлээд тэдгээрийн лавтайг төгс сайнаар мэдэж чадахгүй.

27 Гэвч болгоогтун, хэрэв та нар бүр миний үгсийг туршин, сэрж мөн чадвараа сэргээх аваас, мөн итгэлийн жижиг хэсгийг ч гэсэн бодит болговол, тийм ээ, бүр та нарт итгэх “хүслээс илүү нь байхгүй ч гэсэн, энэ хүслийг өөрсөддөө хөгжихийг, бүр та нар миний үгсийн нэгэн хэсгийг өөртөө байрлуулж чадахаар итгэтлээ зөвшөөр.

28 Эдүгээ, бид үгийг “үртэй зүйрлэх болно. Эдүгээ, хэрэв та нар ⁶зүрх сэтгэлд тань ⁶үр суулгагдаж болохын тулд зай тавьж өгвөөс, болгоогтун, хэрэв энэ нь үнэн үр, эсвээс энэ нь сайн үр аваас, хэрэв та нар Их Эзэний Сүнснийг эсэргүүцэхээр ‘итгэлгүй байдлаараа үүнийг та нар зайлуулахгүй аваас, болгоогтун, энэ нь та нарын цээжинд өсөж эхлэх болно; мөн та нар эдгээр өсөлтийг мэдрээд, та нар өөрсөддөө—Энэ нь сайн үр, өөрөөр хэлбэл үг нь сайн байх ёстой, учир нь энэ нь бодгалийг минь тэлж эхлэв; тийм ээ, энэ нь ⁰ойлголтыг минь гэгээрүүлж эхлэв, тийм ээ, энэ

21б Ифер 12:6.
 в су Найдвар.
 23а Иоел 2:28–29.
 б Мат. 11:25;
 Лук 10:21;

3 Ниф. 26:14–16;
 С ба Г 128:18.
 27а Марк 11:24.
 28а Алма 33:1.
 б су Зүрх.

в Лук 8:11.
 з Мат. 17:20.
 д су Мэдлэг.

нь надад амтат байх болж эхлэв хэмээн хэлж эхлэх болно.

29 Эдүгээ болгоогтун, энэ нь та нарын итгэлийг өсгөх бус уу? Би та нарт хэлнэ, Тийм ээ; гэсэн хэдий ч энэ нь төгс мэдлэгт хүртэл ургаагүй буюу.

30 Гэвч болгоогтун, үр өсөж, мөн соёолж, мөн ургаж эхлэхэд, тэгээд та нар уг үр сайн байх ёстой гэж хэлдэг; учир нь болгоогтун, энэ нь өсдөг, мөн соёолж, мөн ургаж эхэлдэг. Мөн эдүгээ, болгоогтун, энэ нь та нарын итгэлийг хүчирхэгжүүлэхгүй гэж үү? Тийм ээ, энэ нь та нарын итгэлийг хүчирхэгжүүлэх болно: Учир нь би энэ үр сайн гэдгийг мэднэ хэмээн та нар хэлэх болно; учир нь болгоогтун энэ нь соёолж мөн ургаж эхэлдэг.

31 Мөн эдүгээ, болгоогтун, энэ нь сайн үр гэдэг нь та нарт лавтай байна уу? Би та нарт хэлнэ, тийм ээ; учир нь үр болгон өөрийнхөө нэгэн “адил үрийг авчирдаг билээ.

32 Тиймийн тул, хэрэв үр ургавал энэ нь сайн, гэвч хэрэв ургахгүй бол, болгоогтун энэ нь сайн биш, тиймийн тул энэ нь хаягдах болно.

33 Мөн эдүгээ, болгоогтун, та нар туршиж үзсэн, мөн үрийг тарьсан учир, мөн өсөж мөн соёолж, мөн ургаж эхэлсэн учир, та нар үр нь сайн юм гэдгийг мэдэх учиртай.

34 Мөн эдүгээ, болгоогтун, та нарын “мэдлэг төгс үү?

Тийм ээ, та нарын мэдлэг тэр зүйлд төгс, мөн та нарын “итгэл зогсонги; мөн энэ нь та нар мэддэгийн учир, тодруулбал үг нь та нарын сэтгэлийг өсгөсөн болохыг та нар мэднэ, мөн та нарын ойлголт гэгээрүүлэгдэж эхэлдэг, мөн та нарын “оюун тэлж эхэлсэн учир, энэ нь соёолсныг та нар түүнчлэн мэдэх болно.

35 Ай тэгвэл, энэ нь бодитой гэж үү? Би та нарт хэлнэ, Тийм ээ, учир нь энэ бол “гэрэл; мөн гэрэл болгон ямар боловч сайн, учир нь энэ бол харагдах зүйл, тиймийн тул та нар энэ нь сайныг мэдэх ёстой; мөн эдүгээ болгоогтун, та нар энэ гэрлийг амталсны дараа мэдлэг тань төгс үү?

36 Болгоогтун би та нарт хэлнэ, Үгүй; бас та нар итгэлээ орхих ёсгүй, учир нь та нар үрийг сайн эсэхийг мэдэхээр туршин үзэж болохын тулд, зөвхөн үрийг тарихад л итгэлээ бодитой болгосон байдаг.

37 Мөн болгоогтун, мод ургаж эхлэхэд, та нар хэлэх болно: Энэ нь үндэслэж болохын тулд, энэ нь ургаж, мөн бидэнд үр жимс авчирч болохын тулд агуу халамжаар үүнийг арчилцгаая. Мөн эдүгээ болгоогтун, хэрэв та нар үүнийг их халамжаар арчилбаас энэ нь үндэслэн, мөн ургаж, тэгээд үр жимс авчрах болно.

38 Гэвч хэрэв та нар уг

31а Эхл. 1:11–12.

34а су Мэдлэг.

б Ифер 3:19.

в су Оюун.

35а су Иохан 3:18–21.

су Гэрэл, Христийн

гэрэл.

модонд “хайнга хандаж, мөн үүний арчилгааны талаар эс бодвоос, болгоогтун энэ нь үндэслэхгүй байх болно; мөн нарны илч тусаж, мөн түүнийг шарж төөнөхөд, үндэсгүйн учир хатан хувхайрч, мөн та нар үүнийг сугалж, тэгээд үүнийг хаях болно.

39 Эдүгээ, энэ нь үр сайн бус, эсвээс үүний жимс нь дур булаам бус байснаас болсон биш юм; харин энэ нь “газрын чинь үржил шимгүйнх, мөн та нар модыг арчлаагүйнх юм, тиймийн тул та нар үүний жимсийг авч чадахгүй.

40 Мөн тийн, хэрэв үүний жимсийг итгэлийн нүдээр хүсэн хүлээж та нар үгийг арчлахгүй аваас, та нар хэзээ ч “амьдралын модны жимснээс түүж чадахгүй.

41 Гэвч хэрэв та нар үгийг арчилбал, тийм ээ, үүнийг ургаж эхлэхэд модыг арчилж, өөрийн агуу шаргуу итгэл хийгээд “тэвчээрээр үүнийг хүсэн хүлээх аваас, энэ нь үндэслэх болно; мөн болгоогтун энэ нь үүрдийн амьдралд ^бхүргэх мод байх болно.

42 Мөн энэ нь та нарын дотор үндэслэж болохын тулд, та нар үгийг арчлахдаа зориулсан “шаргуу байдал хийгээд та нарын итгэл түүнчлэн та нарын тэвчээрийн учир, болгоогтун, удахгүй та нар үүний ^бжимсийг,

хамгийн эрхэм, амтат бүхнээс дээд амтат, мөн цагаан бүхнээс цагаан түүнийг, тийм ээ, цэвэр бүхнээс цэвэр түүнийг түүх болно; мөн та нар бүр цадталаа, та нар өлсөхгүй, бас цангахгүй болтлоо энэ жимсэн дээр найрлах болно.

43 Тэгээд, ах дүүс минь уг мод та нарт жимс өгөхийг хүлээж байх зуур гаргасан итгэлийнхээ, мөн шаргуу байдлынхаа, мөн тэвчээрийнхээ, мөн тэсвэрийнхээ шагналыг та нар хадаж авах болно.

БҮЛЭГ 33

Хүмүүн залбирч мөн газар бүхэнд шүтэн бишрэх ёстойг, мөн Хүүгийн учир шүүлтүүд зайлуулагдахыг зинос заав— Нигүүлсэл Хүүгийн учир бэлэглэгдсэнийг зинос заав— Бурханы Хүүгийн хэв шинжийг Мосе аглаг буйдад өргөв. Ойролцоогоор мээ 74 он.

Эдүгээ Алма эдгээр үгсийг ярьсны дараа, тэд түүний ярьсан жимсийг хүртэж болохын тулд “нэг Бурханд итгэх ёстой эсэхээ, эсвээс тэдний зүрх сэтгэлд суулгагдах ёстой хэмээн түүний хэлсэн тэрхүү үгийг, өөрөөр хэлбэл ^бүрийг тэд хэрхэн тарих ёстойг; эсвээс ямар маягаар тэд итгэлээ хөгжүүлж эхэлбэл зохихыг мэдэхийг хүсч түүнд илгээв.

2 Мөн Алма тэдэнд хэлэв:

38a су Урвалт.

39a Мат. 13:5.

40a Эхл. 2:9;

1 Ниф. 15:36.

41a су Тэвчээр.

б Алма 33:23;

С ба Г 63:23.

42a су Хичээл зүтгэл.

б 1 Ниф. 8:10–12.

33 1a 2 Ниф. 31:21;

Мозая 15:2–4.

б Алма 32:28–43.

Болгоогтун, та нар синагогуудаасаа хөөгдсөн учир Бурханаа “шүтэн биширч чаддаггүй хэмээн хэлэв. Гэвч болгоогтун, би та нарт хэлнэ, хэрэв та нар Бурханыг шүтэн биширч чаддаггүй хэмээн бодвол, та нар маш ихээр алдаж байна, мөн та нар ^бсудруудыг судалбал зохино; хэрэв та нар тэдгээр нь та нарт үүнийг заасан гэвэл, та нар тэдгээрийг ойлгодоггүй аж.

3 Хуучны бошиглогч “Зинос залбирал эсвээс ^бшүтлэгийн талаар юу хэлснийг уншсанаа санаж байна уу?

4 Учир нь тэр хэлсэн нь: Та нигүүлсэнгүй билээ, Ай Бурхан, учир нь та намайг бүр аглаг буйдад байхад ч залбирлыг минь сонссон; тийм ээ, “дайснууд минь байсан тэдний талаар намайг залбирахад та нигүүлсэнгүй байж, мөн та тэднийг миний зүг эргүүлсэн билээ.

5 Тийм ээ, Ай Бурхан, мөн намайг “талбайдаа танд хандан залбирч байхад та надад нигүүлсэнгүй байсан; намайг залбиралдаа гуйж байхад, мөн та намайг сонссон болой.

6 Мөн үүнчлэн, Ай Бурхан, намайг гэрийнхээ зүг эргэхэд ч та намайг залбиралд минь сонссон болой.

7 Мөн би “гонхондоо орон, Ай Их Эзэн, мөн танд зал-

бирахад, та намайг сонссон болой.

8 Тийм ээ, хүмүүнд бус харин танд сонгохоор залбиран гуйхад нь та хүүхдүүддээ нигүүлсэнгүй байдаг, мөн та тэднийг сонсох болно.

9 Тийм ээ, Ай Бурхан, та надад нигүүлсэнгүй байж, мөн гуйлтуудыг минь өөрийн цугласан олны дундаас сонссон билээ.

10 Тийм ээ, мөн та намайг “зайлуулагдаж мөн дайснуудаараа үзэн ядагдаж байхад та түүнчлэн намайг сонссон; тийм ээ, та гуйлтуудыг минь сонссон, мөн дайснуудад маань уурласан, мөн та тэдэнд уур хилэндээ хурдан устгалаар зочилсон болой.

11 Мөн та зовлонгуудын минь мөн чин сэтгэлийн минь учир намайг сонссон; мөн таны Хүүгийн учир та надад ийн нигүүлсэнгүй байсан, тиймийн тул би өөрийн бүх зовлон дунд танаас гуйх болно, учир нь танд миний баясал буй; учир нь та өөрийн Хүүгийн учир шүүлтүүдээ надаас зайлуулан буцаасан ажгуу.

12 Мөн эдүгээ Алма тэдэнд хэлэв: Та нар хуучны болох тэднээр бичигдсэн “судруудад итгэдэг үү?

13 Болгоогтун, хэрэв тийм бол, та нар “Зиносын хэлсэнд итгэх ёстой; учир нь,

2a Алма 32:5.

б Алма 37:3–10.

3a су Судрууд—

Алдагдсан судрууд;

Зинос.

б су Шүтэн бишрэх.

4a Мат. 5:44.

5a Алма 34:20–25.

7a Мат. 6:5–6;

Алма 34:26.

10a Алма 32:5.

12a су Судрууд.

13a Алма 34:7.

болгоогтун тэрээр хэлсэн нь: Та өөрийн Хүүгийн учир шүүлтүүдээ зайлуулан буцаасан ажгуу.

14 Эдүгээ болгоогтун, ах дүүс минь, та нар судруудыг уншсан эсэхийг би асууя? Хэрэв та нар тэгсэн бол, та нар яахан Бурханы Хүүд итгэлгүй байж чадах билээ?

15 Учир нь Зинос ганцаараа эдгээр зүйлийг ярьсан гэж “бичиглэгдээгүй, харин ^бЗинок түүнчлэн эдгээр зүйлийн талаар ярьсан билээ—

16 Учир нь болгоогтун, тэрээр хэлсэн нь: Өөрийн Хүүгийн учир тэдний дээр бэлэглэсэн тэрхүү нигүүлслүүдийг тань ойлгохгүйн учир энэ хүмүүст та ууртай байна, Ай Их Эзэн.

17 Мөн эдүгээ, ах дүүс минь, та нар хуучны хоёр дахь бошиглогч Бурханы Хүүгийн талаар гэрчилснийг харлаа, мөн уг хүмүүс түүний үгсийг ойлгоогүйн учир түүнийг үхтэл нь “чулуугаар шидсэн ажгуу.

18 Гэвч болгоогтун, энэ нь бүгд бус; зөвхөн эдгээр нь Бурханы Хүүгийн талаар ярьсан тэд биш авай.

19 Болгоогтун, тэрээр “Мосегоор яригдсан бөлгөө; тийм ээ, мөн болгоогтун аглаг буйдад ^бхэв шинж ^вөргөгдсөн, үүнийг харсан хэн боловч

амьдарч болохын тулд юм. Мөн олон нь харж мөн амьдрав.

20 Гэвч тэдгээр зүйлийн утгыг ойлгосон нь цөөн, мөн энэ нь тэдний зүрх сэтгэл хатуугийн учир болой. Харин хатуурсан байснаас харахыг хүсээгүй нь олон байв, тиймийн тул тэд мөхсөн юм. Эдүгээ тэд харахгүй байсны шалтгаан нь, энэ нь тэднийг “эдгээнэ гэдэгт тэд итгээгүйгээс юм.

21 Өө ах дүүс минь, хэрэв та нар эдгээгдэж болохын тулд зөвхөн харц чулуудсанаар эдгээгдэж болдог бол, та нар хурдхан болгоохгүй гэж үү, эсвээс та нар мөхөж болохын тулд та нар харцаа эс чулуудан залхаг байж, итгэлгүй байдалд зүрх сэтгэлээ хатууруулах нь дээр хэмээн үзнэ гэж үү?

22 Хэрэв тийм аваас, та нарын дээр халаг байх болно; гэвч хэрэв тийм бус аваас, тэгвэл харц чулуудан мөн Бурханы Хүүд, тэрээр өөрийн хүмүүсийг гэтэлгэхээр ирэх болно гэдэгт, мөн тэрээр тэдний нүглүүдийг “цагаатгахаар зовж мөн егүүтгэгдэх болно гэдэгт, бүх хүмүүн эцсийн хийгээд шүүлтийн өдөр ^бүйлүүдийнхээ дагуу шүүгдэхээр түүний өмнө зогсохын тулд тэрээр ^вамилуулалтыг

15a Иаков 4:4.

б 1 Ниф. 19:10;

Алма 34:7.

17a су Санаатайгаар алах, Санаатай аллага.

19a Дэд хууль 18:15, 18;

Алма 34:7.

б Тоол. 21:9;

2 Ниф. 25:20;

Мозая 3:15.

в Иохан 3:14;

Хил. 8:14–15.

20a 1 Ниф. 17:40–41.

22a Алма 22:14; 34:8–9.

б су Ажлууд.

в су Амилуулалт.

улируулан тохиолгохоор нас барагсдын дундаас 'босно гэдэгт ^дитгэж эхлэгтүн.

23 Мөн эдүгээ, ах дүүс минь, та нар энэ үгийг зүрх сэтгэлдээ “тариасай, мөн энэ нь ургаж эхлэхэд та нар итгэлээрээ арчлаасай хэмээн би хүснэ. Мөн болгоогтун, энэ нь танд үүрдийн амьдралд ^бнахиалах нэгэн мод болно. Мөн тэгээд түүний Хүүгийн баяслаар танд “үүрэг чинь хөнгөн байж болохыг Бурхан соёрхох болтугай. Мөн хэрэв та нар хүсвэл бүр энэ бүгдийг та нар хийж чадах нь тэр бөлгөө. Амен.

БҮЛЭГ 34

Авралд хүргэх үг Христэд байдгийг Амюлек гэрчлэв—Цагаатгал хийгдээгүй аваас, бүх хүн төрөлхтөн мөхөх ёстой—Мосегийн бүх хууль Бурханы Хүүгийн золиослолын зүг заадаг—Гэтэлгэлийн мөнхийн төлөвлөгөө итгэл хийгээд наманчлал дээр үндэслэдэг—Биеийн мөн сүнсний адислалуудын төлөө залбиратун—Энэ амьдрал хүмүүний хувьд Бурхантай уулзахад бэлтгэх хугацаа болой—Бурханы өмнө эмээж өөрсдийн авралыг гүйцээгтүн. Ойролцоогоор мээ 74 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Алма тэдэнд эдгээр үгсийг ярьсныхаа дараа газар дээр сууж, мөн “Амюлек босож

мөн тэдэнд сургаж эхлэв, өгүүлсэн нь:

2 Ах дүүс минь, биднээр Бурханы Хүү болохыг заагдсан тэр, Христийн ирэлтийн талаар яригдсан зүйлийг үл мэдэх нь боломжгүй хэмээн бодно би; тийм ээ, бидний дундаас та нар тэрслэхээс өмнө “эдгээр зүйл та нарт элбэг дэлбэгээр сургагдсаныг мэднэ би.

3 Мөн та нар зовлонгуудынхаа учир та нар юу хийвэл зохихыг тэрээр та нарт мэдүүлэхийг хайрт ахаас минь хүссэнчлэн; мөн тэрээр та нарын оюуныг бэлтгэхээр зарим зүйлийг та нарт ярьсан билээ; тийм ээ, мөн тэрээр та нарыг итгэлд мөн тэвчээрт ухуулсан бөлгөө—

4 Тийм ээ, бүр та нар үгийг зүрх сэтгэлдээ “тарихаар тийм их итгэлтэй байхад, та нар үүний сайныг нь туршин шалгаж болохын тулд буюу.

5 Мөн уг Бурханы Хүүд байдаг эсэх, эсвээс Христ байх эсэх нь та нарын оюунд их том асуулт болохыг бид ойлгов.

6 Мөн түүнчлэн авралд хүргэдэг “үг Христэд буй гэдгийг ах маань та нарт олон жишээгээр нотолсныг та нар болгоов.

7 Бурханы Хүүгээр гэтэлгэл ирнэ гэсэн Зиносын үгсээс, мөн түүнчлэн Зинокийн үгсээс ах минь иш татав; мөн түүнчлэн тэрээр эдгээр

22г Алма 11:44.
д Алма 32:27–28.
23а Алма 33:1; 34:4.
б Алма 32:41;

С ба Г 63:23.
в Алма 31:38.
34 1а Алма 8:21.
2а Алма 16:13–21.

4а Алма 33:23.
6а Иохан 1:1, 14.

зүйлийг үнэнийг нотлохоор Мосегийнхоос иш татсан болой.

8 Мөн эдүгээ, болгоогтун, эдгээр зүйлийн үнэнийг би өөрөө та нарт “гэрчлэх болно. Болгоогтун, би та нарт хэлнэ, Христ хүмүүний үрсийн дунд өөрийн хүмүүсийн зөрчлүүдийг өөртөө авахын тулд ирэхийг, мөн тэр дэлхийн нүглийг ^бцагаатгах болно гэдгийг би мэднэ; учир нь Их Эзэн Бурхан үүнийг ярьсан билээ.

9 Учир нь ^ацагаатгал хийгдэх нь зайлшгүй юм; учир нь Мөнхийн Бурханы агуу их ^бтөлөвлөгөөний дагуу цагаатгал хийгдэх ёстой, эс бөгөөс бүх хүн төрөлхтөн гарцаагүй мөхөх ёстой; тийм ээ, бүгд хатуурсан; тийм ээ, бүгд ^вунасан мөн төөрөлдсөн, мөн зайлшгүй хийгдэх ёстой уг цагаатгалаар бус аваас мөхөх ёстой.

10 Учир нь агуу их болоод эцсийн “золиослол байх ёстой нь зайлшгүй; тийм ээ, хүмүүний золиослол бус, бас амьтных ч бус, бас ямар ч жигүүртнийх бус болой; учир нь энэ нь хүмүүний золиослол байхгүй; харин энэ нь ^бхэмжээлшгүй хийгээд мөнхийн “золиослол байх ёстой.

11 Эдүгээ өөр нэгний нүглийг цагаатган өөрийн цусыг золиосолж чадах ямар ч хүн

үгүй. Эдүгээ, хэрэв хүмүүн аллага үйлдвэл, болгоогтун “шударга болох манай хууль ахынх нь амийг авна гэж үү? Би та нарт хэлнэ, Үгүй.

12 Гэвч хууль “алсан түүний амийг шаарддаг; тиймийн тул дэлхийн нүглүүдэд хангалттай байх тэр нь хэмжээлшгүй цагаатгалаас өөр юу ч байж эс чадах ажээ.

13 Тиймийн тул, агуу их болоод эцсийн золиослол байх нь зайлшгүй, мөн тэгээд цус урсгахыг “зогсоох зүйл байх болно, өөрөөр хэлбэл энэ нь байвал зохино; чингээд ^бМосегийн хууль гүйцэлдэх болно; тийм ээ, энэ нь бүгд гүйцэлдэх болно, зураас мөн үсэг бүр, мөн юу ч өнгөрөөд л дуусахгүй болой.

14 Мөн болгоогтун, энэ нь “хуулийн бүхэл ^бутга, цэг болгон нь агуу их болоод эцсийн золиослолын зүг заадаг; мөн тэр агуу болоод эцсийн “золиослол нь Бурханы Хүү байх болно, тийм ээ, хэмжээлшгүй бөгөөд үүрдийнх бөлгөө.

15 Мөн тийн тэрээр өөрийн нь нэрэнд итгэх тэд бүгдэд “авралыг авчрах болно; шударга ёсыг давамгайлах тэр, мөн хүмүүнд, тэд наманчлалд итгэлтэй байх тэр замыг авчрах нигүүлслийн зүрх сэтгэлийг бий болгох нь эцсийн золиослолын зорилго юм.

8а су Гэрчлэх.
б су Цагаатгах,
Цагаатгал.

9а Алма 33:22.
б Алма 12:22–33;
Мосе 6:62.

в су Адам Ева хоёрын

Уналт.

10а Мосе 5:6–7.

б 2 Ниф. 9:7.

в су Золиослол.

11а Дэд хууль 24:16;

Мозая 29:25.

12а су Үхлийн

шийтгэл; Аллага.

13а 3 Ниф. 9:17, 19–20.

б 3 Ниф. 15:5.

14а су Мосегийн хууль.

б Алма 30:3.

в С ба Г 138:35.

15а су Аврал.

16 Мөн наманчлалд хүргэх итгэлийг бодитой болгоогүй нь “шударга ёсны шаардлагын бүх л хуульд харьяалагдсан байхад ^бнигүүлсэл нь тийн “шударга ёсны шаардлагыг хангаж, мөн тэднийг аюулгүйн гараар хүрээлж чадна; тиймийн тул зөвхөн наманчлалд хүргэх итгэлтэй түүнд агуу их хийгээд ^ггэтэлгэлийн мөнхийн төлөвлөгөө түүнд үйлчилдэг.

17 Тиймийн тул ах дүүс минь, тэрээр та нарын дээр нигүүлсэнгүй байхын тулд, та нар түүний ариун нэрийг “дуудаж эхлэхийн тулд, наманчлалд хүргэх ^битгэлийг бодитой болгон эхэлж болохыг Бурхан та нарт соёрхох болтугай.

18 Тийм ээ, нигүүлслийн тулд түүнээс гуйцгаа, учир нь тэр аврах хүчтэй билээ.

19 Тийм ээ, өөрсдийгөө даруу болго, мөн түүнд хандан залбирлаа үргэлжлүүлэгтүн.

20 Та нар талбайдаа байхдаа тийм ээ, түүнд хандан, өөрсдийн бүх мал сүргийнхээ төлөө залбиран гуй.

21 Гэртээ түүнд “залбиран гуй, тийм ээ, бүх гэрийнхнийхээ төлөө, өглөө, өдөр мөн үдэш аль алинд нь буюу.

22 Тийм ээ, дайснуудынхаа хүчний эсрэг түүнээс залбиран гуй.

23 Тийм ээ, бүх “зөв шударгын дайсан болох ^бчөтгөрийн эсрэг түүнээс “гуй.

24 Та нар түүгээр дэгжиж болохын тулд өөрсдийн талбай дахь ургацынхаа төлөө түүнээс гуй.

25 Тэдгээр нь өсөж үржихийн тулд төлөө гуй, талбай дахь сүргийнхээ.

26 Гэвч энэ нь бүгд бус; “гонхнууддаа мөн нууц байрнууддаа, мөн аглаг буйддаа та нар өөрсдийн сүнсийг уудлан гаргах ёстой.

27 Тийм ээ, мөн та нар Их Эзэнээс гуйгаагүй үедээ ч, “зүрх сэтгэл чинь ^бдүүрэн байг, аз жаргалынхаа төлөө, мөн түүнчлэн та нарын эргэн тойронд байгаа тэдний аз жаргалын төлөө залбирлаа үргэлжлүүлэн түүнд хандуулж бай.

28 Мөн эдүгээ болгоогтун, хайрт ах дүүс минь, би та нарт хэлнэ, энэ нь бүгд хэмээн бүү бод; учир нь та нар эдгээр бүх зүйлийг хийсний дараа, хэрэв та нар “гачигдсаныг, мөн нүцгэрснийг хоосон буцааж, мөн өвдсөн хийгээд зовсонд үл очин, мөн хэрэв та нарт буй аваас хөрөнгөнөөсөө гачигдсан тэдэнтэй эс ^бхуваалцвал—Би та нарт хэлнэ, хэрэв та нар эдгээр зүйлийн нэгийг ч эс хийвээс,

16a Алма 12:32.

^б су Нигүүлсэнгүй, Нигүүлсэл.

^в су Шударга ёс.

^г су Гэтэлгэлийн төлөвлөгөө.

17a су Залбирал.

^б су Итгэл.

21a Дуул. 5:1–3;

3 Ниф. 18:21.

23a су Зөв шударга,

Зөв шударга байдал.

^б су Чөтгөр.

^в 3 Ниф. 18:15, 18.

26a Мат. 6:5–6.

27a су Зүрх.

^б су Тунгаан бодох.

28a су Ядуу.

^б су Өглөг, Өглөг өгөх.

болгоогтун, “залбирал тань ‘хоосон, мөн та нарт ямар ч хэрэггүй байж, мөн та нар сүсэг бишрэлийг үгүйсгэсэн хоёр нүүртэн лугаа адил байх болно.

29 Тиймийн тул, хэрэв та нар “энэрэнгүй байхыг санахгүй бол, та нар цэвэршүүлэгчдээр хаягддаг новш лугаа адил, (энэ нь ямар ч ашиггүй учир) хүмүүсийн хөл дор дэвслэгдэнэ.

30 Мөн эдүгээ, ах дүүс минь, та нар ийм олон гэрчлэл хүлээн авсныхаа дараа, ариун судрууд эдгээр зүйлийг гэрчилдгийг мэдсэн учир, та нар ирж мөн наманчлалын “үр шимийг авчраасай хэмээнэ би.

31 Тийм ээ, та нар ирж мөн зүрх сэтгэлээ цаашид бүү хатууруулаасай хэмээнэ би; учир нь болгоогтун, та нарын “авралын өдөр мөн үе нь эдүгээ болой; мөн тиймийн тул, хэрэв та нар наманчилж зүрх сэтгэлээ хатууруулахгүй аваас, гэтэлгэлийн агуу их төлөвлөгөө тэр даруй та нарт үйлчлэх болно.

32 Учир нь болгоогтун, энэ амьдрал бол хүмүүн Бурхантай уулзахаар “бэлтгэх үе; тийм ээ, болгоогтун энэ амьдралын өдөр бол хүмүүн өөрсдийн хөдөлмөрийг гүйцэтгэх өдөр юм.

33 Мөн эдүгээ, та нарт миний урьд нь хэлсэнчлэн, та нарт ийм олон гэрчлэл байсан учир, тиймийн тул, эцсийг хүртэл “наманчлалын өдрөө бүү ^бхойшлуулаасай хэмээн би та нараас гуйна; учир нь мөнхийн тулд бэлтгэхээр бидэнд өгөгдсөн амьдралын энэ өдрийн дараа, болгоогтун, хэрэв бид энэ амьдралдаа цагийг сайнаар ашиглахгүй бол, тэгвэл ямар ч хөдөлмөр гүйцэлдэж чадахгүй “шөнийн ‘харанхуй ирэх болно.

34 Тэрхүү аймшигт “хямралд авчрагдсан үедээ би наманчилна хэмээн, би Бурхандаа эргэж очих болно хэмээн та нар хэлж чадахгүй. Үгүй, та нар үүнийг хэлж чадахгүй; учир нь энэ амьдралаас гарах цагт та нарын биесийг эзэмдэж байдаг тэрхүү сүнс, мөнхүү тэр сүнс мөнхийн дэлхийд та нарын биеийг эзэмших хүчтэй байх болно.

35 Учир нь болгоогтун, хэрэв та нар бүр үхлийг хүртэл наманчлалынхаа өдрийг хойшлуулсан бол, болгоогтун, та нар чөтгөрийн сүнсэнд “харьяалагддаг болсон байна; мөн тэрээр та нарыг өөрийн хэмээн ^блацдах болно, тиймийн тул Их Эзэний Сүнс таныг орхин гарч, мөн таны дотор эзлэх зайгүй болж,

28в Мат. 15:7–8.

г Моро. 7:6–8.

29а су Энэрэл.

30а Мат. 3:8;

Алма 13:13.

31а Ром 13:11–12.

32а 2 Ниф. 2:21;

Алма 12:24; 42:4–6.

33а Хил. 13:38;

С ба Г 45:2.

б су Наманчлах,

Наманчлал.

в Иохан 9:4;

С ба Г 45:17.

г су Сүнсний харанхуй; Сүнсний үхэл.

34а Алма 40:13–14.

35а 2 Ниф. 28:19–23.

б 2 Ниф. 9:9.

мөн чөтгөр таны дээр бүх хүчийг эзэмших болно; мөн энэ нь ёс бусыг үйлдэгчдийн сүүлчийн байдал юм.

36 Мөн би үүнийг мэднэ, яагаад гэвэл Их Эзэн өөрөө “ариун бус дуганд үл оршино, харин ^бзөв шударгыг үйлдэгчдийн зүрх сэтгэлд тэрээр оршихыг хэлсэн буюу; тийм ээ, мөн тэрээр түүнчлэн зөв шударгыг үйлдэгчид дахин гадагш гарахгүйгээр түүний хаант улсад суух болно хэмээн хэлжээ; харин тэдний өмсгөл Хурганы цусаар цагаан болгогдох болно.

37 Мөн эдүгээ, хайрт ах дүүс минь, та нар эдгээр зүйлийг санаасай, мөн та нар Бурханы өмнө айдастайгаар өөрсдийн авралыг “гүйцээгээсэй, мөн та нар Христийн ирэлтийг цаашид бүү үгүйсгээсэй хэмээн хүснэ би;

38 Та нар Ариун Сүнсний эсрэг цаашид бүү “гэмцээсэй, харин та нар үүнийг хүлээн аваасай, мөн ^бХристийн нэрийг өөрсөд дээрээ аваасай; та нар өөрсдийгөө бүр тоос шороо мэт даруусган, мөн байж болох газар бүрдээ Бурханыг сүнсэнд бас үнэнд “шүтэн бишрээсэй; мөн та нарын дээр түүний бэлэглэдэг тэрхүү олон нигүүлсэл мөн адислалуудын төлөө та

нар өдөр бүр ‘талархалтайгаар амьдраасай.

39 Тийм ээ, мөн түүнчлэн би та нарт ухуулна, ах дүүс минь, та нар чөтгөрийн “уруу таталтаар зайцуулагдан удирдагдахгүй байж болохын тулд, тэрээр та нарыг давамгайлахгүй байж болохын тулд, та нар эцсийн өдөр түүний хараат болохгүй байж болохын тулд та нар үргэлж залбирахаа ^банхаар; учир нь болгоогтун, тэрээр та нарыг ямар ч “сайн зүйлээр эс шагнадаг билээ.

40 Мөн эдүгээ хайрт ах дүүс минь, “тэвчээртэй байхыг, мөн та нар бүх зүйлийн зовлонгуудыг тэвчихийг; та нарыг үлэмж ядуугийн чинь учир зайлуулдаг тэднийг та нар тэдэнтэй адил нүгэлтнүүд болохгүйн тулд ^бгадуурхахгүй байхыг би та нарт ухуулъя;

41 Харин та нар тэвчээртэй байж, мөн та нар нэгэн өдөр бүх зовлонгуудаасаа амарна гэсэн гуйвшгүй найдлагатайгаар тэдгээр зовлонг тэвчихийг буюу.

БҮЛЭГ 35

Үгийн номлол нь зорамчуудын башир аргыг устгав—Тэд тэгээд хөрвүүлэгдэгсдийг хөөж, тэд

36a Мозая 2:37;
Алма 7:21; Хил. 4:24.
б су Зөв шударга,
Зөв шударга
байдал.
37a Филип. 2:12.
38a су Уруу таталт.

б Мозая 5:8;
Алма 5:38.
в су Шүтэн бишрэх.
г Дуул. 69:30;
С ба Г 59:7.
су Талархалтай,
Талархах, Талархал

өргөх.
39a су Уруу татах, Уруу таталт.
б су Харах, Харуул.
в Алма 30:60.
40a су Тэвчээр.
б С ба Г 31:9.

Жершонд Аммоны хүмүүстэй нэгдэв — Алма хүмүүсийн ёс бусын улмаас харамсав. Ойролцоогоор мээ 74 он.

Эдүгээ улиран тохиох дор Амюлек эдгээр үгсээ төгсгөл болгосны дараа, тэд өөрсдөө цугласан олны дундаас гарч мөн Жершоны нутагт ирэв.

2 Тийм ээ, мөн ах дүүсийн үлдсэн нь, зорамчуудад үгийг номлосныхоо дараа, түүнчлэн Жершоны нутагт ирэв.

3 Мөнхүү улиран тохиох дор зорамчуудын илүү нэр хүндтэй хэсэг өөрсдөд нь номлогдсон үгсийн талаар хамтдаа зөвлөлдсөнийхөө дараа, тэд үгийн учир ууртай байв, учир нь энэ нь тэдний “башир аргыг устгасан ажээ; тиймийн тул тэд үгсийг анхааран сонсмооргүй байсан аж.

4 Мөн тэд илгээж мөн бүх нутаг даяар бүх хүмүүсийг нэгтгэн цуглуулж, мөн яригдсан үгсийн талаар тэдэнтэй зөвлөлдөв.

5 Эдүгээ тэдний захирагчид мөн тэдний санваартнууд хийгээд тэдний багш нар өөрсдийнхөө хүслийн талаар хүмүүст мэдүүлсэнгүй; тиймийн тул тэд нууцаар бүх хүмүүсийн бодлыг олж мэдэв.

6 Мөнхүү улиран тохиох дор тэд бүх хүмүүсийн бодлыг олж мэдсэний дараа, Алма болон түүний ах дүүсээр яригдсан үгсэд таалалтай байсан тэд уг нутгаас зайлуулагдав; мөн тэд олон байв;

мөн тэд түүнчлэн Жершоны нутагт ирэв.

7 Мөнхүү улиран тохиох дор Алма болон түүний ах дүүс тэдэнд тохинуулав.

8 Эдүгээ зорамчуудын хүмүүс Жершонд байсан Аммоны хүмүүст уурлаж, мөн зорамчуудын ерөнхий захирагч машид ёс бус хүн байсан учир, тэдний нутагт очсон тэднийг бүгдийг нутгаасаа хөөж гаргахыг хүсэж Аммоны хүмүүст илгээв.

9 Мөн тэрээр тэднийг олон заналхийллээр сүрдүүлж байв. Мөн эдүгээ Аммоны хүмүүс тэдний үгсээс айсангүй; тиймийн тул тэд тэднийг хөөж гаргасангүй, харин тэд өөрсдөд нь ирсэн зорамчуудын бүх ядуусыг хүлээн авав; мөн тэд тэднийг “асарч, мөн тэднийг хувцаслаж, мөн тэдэнд өвлөх нутгуудыг өгөв; мөн тэд өөрсдийн нь хүслийн дагуу тэдэнд туслах болгов.

10 Эдүгээ энэ нь зорамчуудыг Аммоны хүмүүсийн эсрэг уурлахад өдөөн хатгаж, мөн тэд леменчүүдтэй хутгалдан мөн тэднийг түүнчлэн тэдний эсрэг өдөөн хатгаж эхлэв.

11 Мөн тийн зорамчууд мөн леменчүүд Аммоны хүмүүсийн эсрэг, мөн түүнчлэн нифайчуудын эсрэг дайны бэлтгэлүүдийг хийж эхлэв.

12 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арвандолоо дахь он төгсөв.

13 Мөн Аммоны хүмүүс Жершоны нутгаас гарч одон, мөн Мелекийн нутагт ирж, мөн Жершоны нутагт, тэдгээр нь леменчүүдийн их цэрэгтэй мөн зорамчуудын их цэрэгтэй тэмцэлдэж болохын тулд нифайчуудын их цэрэгт зай тавьж өгөв; мөн тийн шүүгчдийн засаглалын арваннайм дахь онд леменчүүд хийгээд нифайчуудын дунд дайн эхлэв; мөн тэдний дайннуудын “цэдэг хожим өгөгдөх болно.

14 Мөн Алма, мөн Аммон болон тэдний ах дүүс, мөн түүнчлэн Алмагийн хоёр хүү, “олон зорамчуудыг наманчлалд авчрахад Бурханы муртарт зэмсэг болж байсныхаа дараа Зарахемла нутагт эргэж ирэв; мөн наманчлалд авчрагдсан болгон нутгаасаа хөөгдөв; гэвч тэд Жершоны нутагт өвлөх нутагтай болж мөн тэд өөрсдийгөө, мөн эхнэр, мөн хүүхдүүд, мөн нутгаа өмгөөлөхөөр зэвсгээ агсацгаасан байв.

15 Эдүгээ Алма, өөрийн хүмүүсийн алдсын төлөө гашуудан байсан учир нь, тийм ээ, тэдний дунд байсан тэр дайнуудын, мөн цус урсгалтын, мөн зөрчилдөөнүүдийн улмаас болой; хот болгонд бүх хүмүүсийн дунд үгийг тунхаглаж байв, өөрөөр хэлбэл мөн үгийг тунхаглахаар илгээгдсэн учир; мөн хүмүүсийн зүрх сэтгэл хатуурч эхэлснийг, мөн үгийн чандын

учир тэд “гомдож эхэлснийг харсан учир, түүний зүрх сэтгэл үлэмж харамсаж байв.

16 Тиймийн тул, тэрээр тэдэнд тус тусад нь, зөв шударгад хамаарах зүйлүүдийн талаар өөрийн “захиасыг өгч болохын тулд хөвгүүдээ цугларах болгов. Мөн тэдэнд өгсөн зарлигуудынх нь шастир түүний өөрийнх нь цэдгийн дагуу бидэнд байгаа болно.

Хүү Хиламандаа өгсөн Алмагийн зарлигууд оршвой.

36 болон 37 дугаар
бүлэгт агуулагдав.

БҮЛЭГ 36

Алма тэнгэр элчийг харсныхаа дараах өөрийн хөрвүүлгийн тухай Хиламанд гэрчлэв—Тэрээр яллагдсан бодгалийн шаналлыг амссан болой; тэрээр Есүсийн нэрийг дуудаж, мөн тэгээд Бурханаар төрөв—Амтат баясал түүний бодгалийг дүүргэв—Тэрээр тоолцогүй олон тэнгэр элч Бурханыг магтан дуулж байхыг харав—Олон хөрвөгчид түүний үзэж мөн амссаны адилыг үзэж мөн амсав. Ойролцоогоор мээ 74 он.

“Хүү минь, миний үгсэд чих тавин сонс; учир нь та нар Бурханы зарлигуудыг дагахын хэрээр та нар уг нутагт дэгжих болно хэмээн би чамд тангараглаж байна.

2 Эцэг өвгөдийнхөө боолчлолыг санахдаа миний хийснийг чамайг хийгээсэй хэмээнэ би, учир нь тэд “дарангуйлалд байлаа, мөн ⁶Абрахамын Бурхан, мөн Исаакийн Бурхан, мөн Иаковын Бурханаас өөр хэн ч тэднийг чөлөөлж чадахгүй байв; мөн тэрээр тэднийг зовлонгуудаас нь лавтайяа чөлөөлсөн бөлгөө.

3 Мөн эдүгээ, Ай Хиламан хүү минь, болгоогтун, чи залуугаараа байна, мөн тиймийн тул, би чамайг үгсийг минь сонсож мөн надаас сураасай хэмээн чамаас хүсэж байна; учир нь Бурханд найдлага тавьсан хэн боловч өөрсдийн зүдгүүрүүдэд, мөн өөрсдийн бэрхшээлүүдэд хийгээд өөрсдийн “зовлонгуудад дэмжигдэх болно, мөн эцсийн өдөр ⁶өргөгдөх болно гэдгийг би мэднэ.

4 Мөн би өөрөөрөө “мэднэ гэж чамайг бүү бодоосой хэмээнэ би—биеийнхээр бус харин сүнснийхээр, ⁶эгэл оюунаар бус харин Бурханаар бөлгөө.

5 Эдүгээ, болгоогтун, би чамд хэлнэ, хэрэв би Бурханаар “төрөөгүй сэн бол би эдгээр зүйлийг ⁶мэдэхгүй байсан; гэвч Бурхан ариун тэнгэр элчийнхээ амаар эдгээр зүйлийг надад мэдүүл-

сэн юм, өөрийн минь “зохистойн учир бус болой;

6 Учир нь би Мозаягийн хөвгүүдтэй, Бурханы сүмийг “устгахыг эрэлхийлсээр явж байсан; гэвч болгоогтун, Бурхан биднийг замд нь зогсоохоор ариун тэнгэр элчээ илгээсэн юм.

7 Мөн болгоогтун, тэрээр бидэнд аянгын дуу хоолойгоор мэт ярьж, мөн бидний хөл доорх бүх л дэлхий “чичирсэн билээ; мөн бид бүгд газарт унав, учир нь Их Эзэнээс айх ⁶айдас бидний дээр ирэв.

8 Гэвч болгоогтун, уг дуу хоолой надад хэлэв: Босогтун. Мөн би босож мөн зогсоод, мөн нэгэн тэнгэр элчийг болгоов.

9 Мөн тэрээр надад хэлэв: Та өөрийгөө устгуулахыг хүслээ ч, Бурханы сүмийн устгалыг цаашид бүү эрэлхийл.

10 Мөнхүү улиран тохиох дор би газарт унав; мөн “гурван өдөр бас гурван шөнийн турш би амаа нээж ч, бас үе мөчөө хөдөлгөж ч чадсангүй.

11 Мөн уг тэнгэр элч надад ах дүүсийн минь сонссон тэрхүү илүү зүйлийг ярив, гэвч би тэдгээрийг сонссонгүй; учир нь би—та өөрийгөө устгуулахыг хүслээ ч Бурханы сүмийн устгалыг цаашид бүү эрэлхийл—гэсэн үгсийг

2а Мозая 23:23;
24:17–21.
б Ег. 3:6; Алма 29:11.
3а Ром 8:28.
б Мозая 23:21–22.
4а 1 Кор. 2:11;
Алма 5:45–46.

сү Мэдлэг.
б су Тачаангуй,
Зуурдын.
5а су Дахин төрөх,
Бурханаас төрөх.
б Алма 26:21–22.
в су Зөв зохистой,

Зөв зохистой
байдал.
6а Мозая 27:10.
7а Мозая 27:18.
б су Айх, эмээх—
Бурханаас эмээх.
10а Мозая 27:19–23.

дуулаад би магад устгагдах болов уу хэмээн, бүр тийм их айдас мөн гайхашралдаа цочирдсоноос би газарт унаж мөн цаашид юу ч сонссонгүй.

12 Гэвч би “мөнхийн зовлонд тамлагдаж байлаа, учир нь бодгаль минь хамгийн их хэмжээгээр тарчлагдаж мөн өөрийн бүх нүглүүдээр тамлагдав.

13 Тийм ээ, би өөрийн бүх нүглүүд мөн алдсуудыг санаж байв, үүний учир би тамын өвдөлтөөр “тарчлагдаж байлаа; тийм ээ, би Бурханыхаа эсрэг тэмцсэнээ, мөн би түүний ариун зарлигуудыг дагаагүйгээ ойлгосон юм.

14 Тийм ээ, мөн би түүний хүүхдүүдээс олныг нь хөнөөсөн, өөрөөр хэлбэл устгал уруу тэднийг удирдсан болой; тийм ээ, мөн эцэст нь, Бурханыхаа дэргэд ирнэ гэдэг тэр л бодол бодгалийг минь илэрхийлэхийн аргагүй аймшигтайгаар тарчилгахаар миний алдсууд ийм агуу байв.

15 Ай, би бодов, би “цөлөгдөж мөн сүнсээр мөн биеэрээ ч үл орших болж чаддаг болоосой, би ^бүйлсээрээ шүүгдэхээр, Бурханыхаа дэргэд зогсохоор аваачигдахгүй байж болохын тулд.

16 Мөн эдүгээ, гурван өдөр мөн гурван шөнийн турш,

бүр “яллагдсан бодгалийн өвдөлтөөр би тарчлав.

17 Мөнхүү улиран тохиох дор би тийн зовлонд тамлагдаж, өөрийн олон нүглийн дурсамжиндаа “тарчлагдаж байдаа би, болгоогтун, би түүнчлэн дэлхийн нүглүүдийг цагаатгахаар, Бурханы Хүү, Есүс Христ гэгч нэгний ирэлтийн талаар хүмүүст эцгийнхээ бошиглохыг дуулснаа санав.

18 Эдүгээ, миний оюун энэ бодол дээр тогтож тунгаах зуур, би зүрх сэтгэлдээ хашгирч: Ай Есүс, Бурханы Хүү та, “шаналлын гүнд буй, мөн үүрдийн үхлийн ^бгинжээр ороогдсон намайг нигүүлсээч гэв.

19 Мөн эдүгээ, болгоогтун, би үүнийг бодмогц, би өвчнөө цаашид санаж чадсангүй; тийм ээ, би нүглүүдийнхээ санамжинд цаашид “тарчлагдахгүй болов.

20 Мөн ай ямар “баясал, мөн ямар гайхамшигт гэрлийг болгоосон билээ би; тийм ээ, бодгаль минь ямархуу шаналалд байсан лугаа адил тийм үлэмжийн баяслаар дүүргэгдсэн байв!

21 Тийм ээ, би чамд хэлнэ, хүү минь, миний шаналал шиг тийм хурц мөн ийм гашуун нь байх аргагүй биз ээ. Тийм ээ, мөн дахин би чамд хэлнэ, хүү минь, нөгөө

12а С ба Г 19:11–15.

13а су Гэм.

15а Илч. 6:15–17;

Алма 12:14.

б Алма 41:3;

С ба Г 1:9–10.

16а су Ял.

17а 2 Кор. 7:10.

18а ө.х. Туйлын их харуусал.

б 2 Ниф. 9:45; 28:22;

Алма 12:11;

Моце 7:26.

19а су Гэм.

20а су Баяр баясгалан.

талаасаа бол миний баясал шиг ийм хурц бас амтлаг юм юу ч байж чадахгүй биз ээ.

22 Тийм ээ, Бурхан сэнтий дээрээ Бурханаа магтан дуулах байдалтай тоо томшгүй олон тэнгэр элчээр хүрээлүүлэн сууж байхыг бүр бидний эцэг “Лихай үзсэний адил би харсан хэмээн бодсон; тийм ээ, мөн бодгаль минь тэнд байхаар тэмүүлсэн бөлгөө.

23 Гэвч болгоогтун, миний үе мөчүүд дахин “хүчээ олж, мөн би хөл дээрээ босож, мөн би “Бурханаар төрлөө гэдгээ хүмүүст мэдүүлэв.

24 Тийм ээ, мөн тэр цагаас бүр одоог хүртэл, би бодгалиудыг наманчлалд авчирч болохын тул; өөрийн амталсан тэр үлэмжийн баяслаас “амтлахад тэднийг авчирч болохын тул; тэд түүнчлэн Бурханаар төрж, мөн Ариун Сүнсээр “дүүргэгдэж болохын тул зогсолтгүйгээр хөдөлмөрлөсөөр ирсэн билээ.

25 Тийм ээ, мөн эдүгээ болгоогтун, Ай хүү минь, Их Эзэн хөдөлмөрийн минь үр шимд үлэмжийн агуу баяслыг надад өгдөг билээ;

26 Учир нь түүний надад мэдүүлсэн тэрхүү “үгийн учир, болгоогтун, олон нь Бурханаар төрж, мөн миний амталсныг амталсан, мөн миний үзсэнийг нүдээрээ

үзэв; тиймийн тул тэд миний ярьсан эдгээр зүйлийг миний мэддэгийн адил мэддэг бөлгөө; мөн надад буй мэдлэг бол Бурханаас юм.

27 Мөн би зүйл бүрийн зүдгүүр хийгээд бэрхшээлүүдийн доор, тийм ээ, мөн төрөл бүрийн зовлонгуудад дэмжигдсэн буюу; тийм ээ, Бурхан намайг шоронгоос, мөн хүлээснээс, мөн үхлээс чөлөөлсөн бөлгөө; тийм ээ, мөн би түүнд найдлага тавьдаг, мөн тэрээр намайг “чөлөөлсөөр байх болно.

28 Мөн тэр эцсийн өдөр намайг өөртэйгөө хамт алдар сууд оршихоор “өргөх болно гэдгийг би мэднэ; тийм ээ, мөн би түүнийг үүрд “магтах болно, учир нь тэрээр бидний эцэг өвгөдийг Египетээс “гарган авчирч, мөн тэрээр “египетчүүдийг Улаан Тэнгист залгиулсан билээ; мөн тэрээр тэднийг өөрийн хүчээр амлагдсан нутагт орох хүртэл удирдсан билээ; тийм ээ, мөн тэрээр тэднийг цагаас цагт дарангуйллаас мөн боолчлолоос чөлөөлөн гаргасаар байсан шүү дээ.

29 Тийм ээ, мөн түүнчлэн тэрээр бидний эцэг өвгөдийг Иерусалим нутгаас гарган авчирсан; мөн түүнчлэн тэрээр, өөрийн үүрдийн хүчээр, тэднийг дарангуйллаас мөн “боолчлолоос цагаас цагт бүр

22a 1 Ниф. 1:8.

23a Мосе 1:10.

б Алма 5:14.

су Дахин төрөх,

Бурханаас төрөх.

24a 1 Ниф. 8:12;

Мозая 4:11.

б 2 Ниф. 32:5;

3 Ниф. 9:20.

су Ариун Сүнс.

26a Алма 31:5.

27a Дуул. 34:17.

28a 3 Ниф. 15:1.

б су Алдар суу.

в Ег. 12:51.

г Ег. 14:26–27.

29a Мозая 24:17; 27:16;

Алма 5:5–6.

эдүгээ өдрийг хүртэл чөлөөлсөөр ирсэн; мөн би тэдний боолчлолыг санаандаа үргэлж хадгалсаар байдаг; тийм ээ, мөн түүнчлэн та нар миний адилаар, тэдний боолчлолыг санаандаа хадгалж байвал зохино.

30 Гэвч болгоогтун, хүү минь, энэ нь бүгд бус; учир нь та нар миний мэдэж байгааг, Бурханы зарлигуудыг дагахын “хэрээр та нар нутагтаа дэгжих болно гэдгийг мэдвэл зохино; мөн та нар түүнчлэн, та нар Бурханы зарлигуудыг дагахгүй байхын хэрээр та нар түүний дэргэдээс тусгаарлагдах болно гэдгийг мэдвэл зохино. Эдүгээ энэ нь түүний үгийн дагуу билээ.

БҮЛЭГ 37

Гуулин ялтсууд хийгээд бусад судрууд бодгалиудыг авралд авчрахаар хадгалагдан үлдсэн бөлгөө — Жаредчууд өөрсдийн ёс бусын улмаас устгагдав — Тэдний нууц ам тангаргууд мөн гэрээнүүд хүмүүсээс нууцлагдах ёстой — Өөрийн бүх үйлүүддээ Их Эзэнтэй зөвлө — Лиахона нифайчуудыг удирдсаны адилаар, тийн Христийн үг хүмүүсийг мөнх амьдрал тийш удирддаг. Ойролцоогоор мээ 74 он.

Мөн эдүгээ, Хиламан хүү минь, надад “итгэмжлэгдсэн

^бцэдгүүдийг чамайг авахыг би чамд тушааж байна;

2 Мөн түүнчлэн энэ хүмүүсийн цэдгийг миний хийсний адилаар, Нифайн ялтсууд дээр хөтлөхийг, бүр би тэдгээрийг хадгалсны адил мөн миний хадгалсан эдгээр бүх зүйлийг эрхэмлэн хадгалахыг би чамд тушааж байна; учир нь тэдгээрийн хадгалагддаг нь “мэргэн зорилгын тулд болой.

3 Мөн бүр эхлэлээс бидний өвөг дээдсийн удмын бичгийг агуулдаг, дээр нь ариун судруудын цэдгүүд байдаг, эдгээр сийлбэрүүдийг тээдэг эдгээр гуулин “ялтсуудыг —

4 Болгоогтун, тэдгээр нь хадгалагдаж мөн нэг үеэс нөгөөд гардуулагдан, тэдгээрт тээгдсэн “нууцуудыг тэд мэдэж болохын тулд, тэдгээр нь үндэстэн, ястан, хэлтэн, мөн хүмүүс болгонд очих хүртэл Их Эзэний мутраар хадгалагдаж мөн хамгаалагдах нь бидний эцэг өвгөдөөр бошиглогдсон буюу.

5 Мөн эдүгээ болгоогтун, хэрэв тэдгээр нь хадгалагдах аваас гялалзсан өнгөтэй хэвээр байх ёстой; тийм ээ, мөн тэдгээр нь гялалзсан өнгөтэй хэвээр байх болно; тийм ээ, мөн ариун бичиг болох түүнийг тээсэн тэр бүх ялтсууд түүнчлэн тийм байх болно.

6 Эдүгээ энэ нь миний хувьд “мунхаглал хэмээн чи бодож

30а 2 Ниф. 1:9–11;
Алма 50:19–22.
37 1а Мозая 28:20.
б Алма 45:2–8.

2а Инос 1:13–18;
Мор. үгс 1:6–11;
Алма 37:9–12.
3а 1 Ниф. 5:10–19.

су Гуулин ялтсууд.
4а су Бурханы
нууцууд.
6а 1 Кор. 2:14.

болно; гэвч болгоогтун, ^бөчүүхэн мөн энгийн зүйлүүдээр агуу их зүйлүүд улиран авчрагддагийг би чамд хэлнэ; мөн өчүүхэн зүйлүүд олон тохиолдолд мэргэдийг гутаадаг бөлгөө.

7 Мөн Их Эзэн Бурхан өөрийн агуу хийгээд мөнхийн зорилгуудыг тохиолдуулах “аргаар ажилладаг; мөн маш ^бөчүүхэн аргаар Их Эзэн мэргэдийг ичээж мөн олон бодгалийн авралыг авчирдаг.

8 Мөн эдүгээ, эдгээр зүйл одоог хүртэл хамгаалагдан үлдсэн байх нь Бурханы мэргэн ухаан билээ; учир нь болгоогтун, тэдгээр нь энэ хүмүүсийн “ой ухааныг тэлж, тийм ээ, мөн тэдний олонд замуудынх нь алдааг ойлгуулж; мөн тэднийг бодгалийнх нь авралд хүргэхээр Бурханых нь мэдлэгт авчирсаар ирсэн юм.

9 Тийм ээ, би чамд хэлнэ, эдгээр ялтсууд дээрх, эдгээр цэдгүүдийг тээсэн, энэ зүйлүүд “үгүй аваас, Аммон болон түүний ах дүүс тийм олон мянган леменчүүдэд тэдний эцэг өвгөдийн зөв бус уламжлалын талаар ^бүнэмшүүлж чадахгүй байсан; тийм ээ, эдгээр цэдгүүд мөн ^бүгс нь тэднийг наманчлалд авчирсан ажгуу; тэдгээр нь тэднийг Их Эзэн Бурханых нь мэдлэгт

мөн Есүс Христ өөрсдийн Гэтэлгэгчдээ баясахад тэднийг хүргэсэн болой.

10 Мөн тэдний олон мянгыг нь, тийм ээ, мөн зүрх сэтгэлээ нүгэлд мөн алдсуудад эдүгээ хатууруулаад буй тэд бидний зөрүүд ах дүүс нифайчуудаас түүнчлэн олон мянгыг нь тэдний Гэтэлгэгчийн тухай мэдлэгт авчрахад тэдгээр нь хэрэгсэл болох эсэхийг хэн мэдэх билээ?

11 Эдүгээ эдгээр нууцууд надад хараахан бүрэн дүүрэн мэдүүлэгдээгүй байна; тиймийн тул би түдгэлзэх болно.

12 Мөн хэрэв тэдгээр нь Бурханы мэдэх тэрхүү зорилго болох мэргэн зорилгын тулд хадгалагдан үлдсэнийг би хэлбэл хангалттай байх; учир нь тэрээр өөрийн бүх бүтээлүүддээ мэргэн ухаанаар “зөвлөдөг, мөн түүний замууд шулуун, мөн түүний замнал нь нэгэн ^бмөнхийн эргэлт авай.

13 Ай Хиламан хүү минь, Бурханы зарлигууд ямар “чанд болохыг санагтун, санагтун. Мөн тэрээр хэлсэн нь: ^бХэрэв та нар миний зарлигуудыг дагавал та нар уг нутагт ^бдэгжих болно— харин хэрэв та нар түүний зарлигуудыг дагахгүй аваас та нар түүний дэргэдээс тусгаарлагдах болно.

6б 1 Ниф. 16:28–29;
С ба Г 64:33;
123:15–17.

7а Иса. 55:8–9.

б Хаад. дэд 5:1–14.

8а 2 Тим. 3:15–17;
Мозая 1:3–5.

9а Мозая 1:5.

б Алма 18:36; 22:12.

в су Сайн Мэдээ.

12а 2 Ниф. 9:28;

Иаков 4:10.

б 1 Ниф. 10:19;
Алма 7:20.

13а 2 Ниф. 9:41.

б Алма 9:13;

3 Ниф. 5:22.

в Мозая 1:7;

Алма 50:20.

14 Мөн эдүгээ, “ариун нандин агаад, түүний нандигнан хадгалсаар ирсэн, мөн түүнчлэн тэрээр ирээдүйн үеийнхэнд өөрийнхөө хүчийг үзүүлж болохын тулд, тэрээр өөрийн “мэргэн зорилгын тулд хадгалж мөн хамгаалсаар байх эдгээр зүйлийг Бурхан чамд “даатгасныг санагтун, хүү минь.

15 Мөн эдүгээ болгоогтун, хэрэв чи Бурханы зарлигийг зөрчих аваас, болгоогтун, ариун нандин эдгээр зүйл чамаас Бурханы хүчээр хураагдаж, мөн Сатан чамайг будааны хальс мэт салхинд хийсгэж болохын тулд чи түүнд хүргэгдэх болно гэдгийг бошиглолын суу билгээр би чамд хэлнэ.

16 Гэвч хэрэв чи Бурханы зарлигуудыг дагаж, мөн ариун нандин эдгээр зүйлүүдээр Их Эзэн чамд зарлигласны дагуу хийх аваас, (учир нь чи тэдгээрээр юу хийх ёстой тэр бүх зүйлийн төлөө Их Эзэнд хандах ёстой) болгоогтун, газрын эсвээс тамын ямар ч хүч тэднийг чамаас “салган авч чадахгүй, учир нь Бурхан өөрийн бүх үгсийг гүйцэлдүүлэхээр хүчирхэг болгоо.

17 Учир нь тэрээр чамд өгөх тэр бүх амлалтуудаа гүйцэлдүүлэх болно, учир нь тэрээр бидний эцэг өвгөдөд өгсөн амлалтуудаа гүйцэлдүүлсэн билээ.

18 Учир нь тэрээр өөрийн хүчийг ирээдүйн үеийнхэнд үзүүлж болохын тулд, өөрт буй мэргэн зорилгын улмаас эдгээр зүйлийг “хадгалан үлдэнэ гэдгийг тэдэнд амласан болой.

19 Мөн эдүгээ болгоогтун, бүр леменчүүдээс “олон мянгыг нь үнэний мэдлэгт сэргээхэд тэрбээр нэгэн зорилгоо гүйцэлдүүлсэн билээ; мөн тэрээр тэднээр өөрийн хүчийг үзүүлж, мөн түүнчлэн тэрээр тэднээр өөрийн хүчийг “ирээдүйн үеийнхэнд ч бас үзүүлэх болно; тиймийн тул тэдгээр нь хадгалагдан үлдэх болно.

20 Тиймийн тул би чамд зарлиглана, Хиламан хүү минь, миний бүх үгсийг гүйцэлдүүлэхдээ хичээнгүй бай, мөн тэдгээрийн бичигдсэний дагуу Бурханы зарлигуудыг дагахдаа чи хичээнгүй бай.

21 Мөн эдүгээ, би чамд тэдгээр “хорин дөрвөн ялтсын талаар ярья, нууцууд хийгээд харанхуйн ажлууд, мөн тэдний “нууц ажлууд, өөрөөр хэлбэл устгагдсан тэдгээр хүмүүсийн нууц ажлуудыг энэ хүмүүст мэдүүлж болохын тулд чи тэдгээрийг хадгалах болно; тийм ээ, тэдний бүх аллага, мөн дээрэм, мөн тонуулууд хийгээд тэдний бүх ёсон бус мөн жигшүүрт хэргүүд энэ хүмүүст мэдүүлэгдэж болохын учир; тийм

14a су Ариун.
б 1 Ниф. 9:3–6.
в С ба Г 3:5.
16a ИС—Т 1:59.

18a С ба Г 5:9.
19a Алма 23:5.
б Инос 1:13;
Морм. 7:8–10.

21a Ифер 1:1–5.
б су Нууц
хуйвалдаанууд.

ээ, мөн чи эдгээр “хөрвүүлэгчдийг хадгалан үлдээж болохын тулд бөлгөө.

22 Учир нь болгоогтун, Их Эзэн өөрийнх нь хүмүүс харанхуйд үйлдэхийг, тийм ээ, нууц аллага, мөн жигшүүрт хэргүүдийг үйлдэж эхлэхийг харсан билээ; тиймийн тул, хэрэв тэд наманчлахгүй аваас тэд газрын гадаргуугаас устгагдах болно хэмээн Их Эзэн хэлсэн юм.

23 Мөн Их Эзэн хэлсэн нь: Надад үйлчлэх өөрийн хүмүүстээ мэдүүлж болохын тулд, би тэдэнд ах дүүсийнх нь үйлүүдийг, тийм ээ, тэдний нууц үйлийг, мөн тэдний харанхуйн үйлүүдийг, мөн тэдний ёс бус жигшүүрт хэргүүдийг мэдүүлж болохын тулд би өөрийн зарц Газелемд, харанхуйг гэрлээр гийгүүлэх “чулууг бэлтгэн өгөх болно.

24 Мөн эдүгээ, хүү минь, эдгээр хөрвүүлэгчид нь Бурханы ийн хэлсэн үг гүйцэлдэж болохын тул бэлтгэгдсэн юм, хэлрүүн:

25 Би тэдний бүх нууц үйл мөн жигшүүрт хэргүүдийг харанхуйгаас гэрэлд “гарган авчрах болно; мөн тэд наманчлахгүй аваас би тэднийг газрын гадаргуугаас “устгах болно; мөн хойшид уг нутгийг эзэмших үндэстэн бүрд, тэдний бүх нууц мөн жигшүүрт хэргүүдийг би гэрэлд гарган мэдүүлэх болно.

26 Мөн эдүгээ, хүү минь, тэд наманчлаагүйг бид харж байна; тиймийн тул тэд устгагдсан ажгуу, мөн одоог хүртэл Бурханы үг гүйцэлдсээр ирсэн билээ; тийм ээ, тэдний нууц жигшүүрт хэргүүд харанхуйгаас авчрагдаж мөн бидэнд мэдүүлэгдсэн бөлгөө.

27 Мөн эдүгээ, хүү минь, чи тэдний бүх тангараг, мөн тэдний гэрээ, мөн тэдний нууц жигшүүрт хэргүүд дэх хэлэлцээрүүдийг нууцал хэмээн би чамд зарлиглаж байна, тийм ээ, тэд тэдгээрийг мэдэхгүй байхын тулд, тэд харанхуйд унаж түүнчлэн мөн устгагдах вий хэмээхийн учир тэдний бүх “дохио хийгээд гайхашралуудыг энэ хүмүүсээс чи нуух болно.

28 Учир нь болгоогтун, тэд үйлдээ бүрэн боловсрох үед харанхуйг үйлдэгч тэд бүгдийн дээр Бурханы хүчний дагуу устгал ирнэ гэсэн “зүхэл энэ бүх нутгийн дээр буй; тиймийн тул энэ хүмүүс устгагдахгүй байгаасай хэмээн би хүсч байна.

29 Тиймийн тул чи тэдний эдгээр гэрээ хийгээд “тангаргийнх нь нууц төлөвлөгөөнүүдийг энэ хүмүүсээс далдал, мөн зөвхөн тэдний ёс бус байдал хийгээд тэдний аллагууд мөн тэдний жигшүүрт хэргүүдийг л чи тэдэнд мэдүүлэх болно; мөн чи тэдэнд тийм ёс бус мөн жигшүүрт хэргүүд хийгээд

21в су Урим ба
Туммим.
23а Мозая 8:13.

25а С ба Г 88:108–110.
б Мозая 21:26.
27а Хил. 6:22.

28а Алма 45:16;
Ифер 2:7–12.
29а Хил. 6:25.

аллагуудыг ^бжигшин ээвүүцэхийг заах болно; мөн түүнчлэн эдгээр хүмүүс өөрсдийн ёс байдал бус мөн жигшүүрт хэргүүд мөн өөрсдийн аллагуудын улмаас устгагдсан хэмээн чи тэдэнд заах болно.

30 Учир нь болгоогтун, тэд өөрсдийнх нь дунд тэдний алдсуудынх нь талаар тэдэнд тунхаглахаар ирсэн Их Эзэний бүх бошиглогчдыг хөнөөсөн юм; мөн тэдний хөнөөсөн тэдний цус өөрсдийнх нь алуурчдын дээр өс хонзон авчрахын тулд Их Эзэн Бурхандаа хандан хашгирсан болой; мөн тийн Бурханы шүүлт эдгээр харанхуйг мөн нууц хуйвалдааныг үйлдэгсдийн дээр ирсэн юм.

31 Тийм ээ, мөн тэд үйлдээ боловсорч гүйцэхээсээ өмнө наманчлахгүй аваас, тэдгээр харанхуйг хийгээд нууц хуйвалдааныг үйлдэгсдэд, бүр устгагдах болтол нь уг нутаг үеийн үед мөн үүрд зүхэгдэг.

32 Мөн эдүгээ, хүү минь, чамд миний ярьсан үгсийг санагтун; тэдгээр нууц төлөвлөгөөнүүдийг энэ хүмүүст бүү даатга, харин тэдэнд нүглийн хийгээд алдсын эсрэг үүрдийн “үзэн ядалтыг сурга.

33 Наманчлал, мөн Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг тэдэнд “номло; өөрсдийгөө даруусгаж мөн зүрх сэтгэлдээ даруу мөн ^бномхон байхыг

тэдэнд заа; чөтгөрийн “уруу таталт болгоныг, Их Эзэн Есүс Христэд итгэх өөрсдийн итгэлээр сөрөн зогсохыг тэдэнд заа.

34 Сайн үйлүүдээс хэзээ ч үл залхаж, харин зүрх сэтгэлдээ даруу, номхон дөлгөөн байхыг тэдэнд заа; тиймүүд нь өөрсдийн бодгальд “амар амгаланг олохын учир болой.

35 Ай, санагтун, хүү минь, мөн насны залууд “мэргэн ухаанд суралц; тийм ээ, насны залууд Бурханы зарлигуудыг дагаж сурагтун.

36 Тийм ээ, мөн өөрт хэрэгтэй бүх дэмжлэгийн тулд Бурханаас “гуй; тийм ээ, бүхий л үйлүүд тань Их Эзэний төлөө байг, мөн чи хаана ч явсан Их Эзэнтэй нэгдмэл юм; тийм ээ, бүх бодол санаа чинь Их Эзэнд чиглэсэн байг; тийм ээ, зүрх сэтгэлийн тань хайр Их Эзэн дээр үүрд байрлаг.

37 Бүх үйлүүдээ Их Эзэнтэй “зөвлөгтүн, мөн тэрээр чамайг сайны төлөө чиглүүлэх болно; тийм ээ, чи үдэш унтахаар хэвтэхдээ, тэрээр нойронд чинь чамайг манаж болохын тулд Их Эзэний төлөө хэвт; мөн өглөө босохдоо зүрх сэтгэл чинь Бурханд хандах ^бталархлаар дүүрэн байг; мөн хэрэв чи эдгээр зүйлийг хийх аваас эцсийн өдөр өргөгдөх болно.

38 Мөн эдүгээ, хүү минь,

29б Алма 13:12.

32а 2 Ниф. 4:31.

33а су Номхон

б су Номхон

дөлгөөн, Номхон

дөлгөөн байдал.

в су Уруу татах,

Уруу таталт.

34а Дуул. 37:4–7;

Мат. 11:28–30.

35а су Мэргэн ухаан.

36а су Залбирал.

37а Иаков 4:10;

С ба Г 3:4.

б С ба Г 46:32.

бидний эцэг өвгөдийн бөм-
бөрцөг эсвээс чиглүүлэгч гэж
нэрлэсэн тэр зүйлийн талаар
хэлэх зарим зүйл надад буй —
өөрөөр хэлбэл бидний эцэг
өвгөд үүнийг “Лиахона, хөр-
вүүлбээс луужин гэж нэрлэ-
сэн юм; мөн Их Эзэн үүнийг
бэлтгэсэн бөлгөө.

39 Мөн болгоогтун, иймэр-
хүү маягийн нарийн урыг
ямар ч хүн бүтээж чадахгүй.
Мөн болгоогтун, энэ нь аглаг
буйдад аялах тэдний замыг
бидний эцэг өвгөдөд үзүүлэ-
хийн тулд бэлтгэгдсэн ажгуу.

40 Мөн энэ нь тэдний төлөө
Бурханд итгэх “итгэлийнх нь
дагуу ажилладаг байжээ; тий-
мийн тул, хэрэв тэд Бурхан
тэр зүүнүүдээр тэдний явах
ёстой замыг заалгаж чадна гэ-
сэн итгэлтэй байвал, болгоог-
тун, энэ нь хийгддэг байжээ;
тиймийн тул тэдэнд энэхүү
гайхамшиг, мөн түүнчлэн
бусад олон гайхамшиг Бур-
ханы хүчээр өдөр өдрөөр
авчрагдсан бөлгөө.

41 Гэсэн хэдий ч, тэдгээр
гайхамшгууд “өчүүхэн арга
хэрэгслүүдээр гүйцэлдсэн
учир энэ нь тэдэнд ер бусын
ажлуудыг үзүүлсэн бөлгөө.
Тэд хойрго байж, мөн итгэ-
лээ бас хичээнгүй байдлаа
бодитой болгохоо мартсан
юм, мөн тэгээд тэдгээр ер
бусын ажлууд зогссон билээ,
мөн тэд аян замдаа ураг-
шилсангүй;

42 Тиймийн тул, тэд өөр-
дийн зөрчлүүдийн учир тэд
аглаг буйдад саатаж, өөрөөр
хэлбэл чиг замаа шууд хөө-
сөнгүй, мөн өлссөнөөс бас
цангаснаас зовоогдож байв.

43 Мөн эдүгээ, хүү минь, би
чамайг эдгээр зүйл далд ут-
гагүй бус хэмээн ойлгоосой
хэмээнэ; учир нь бидний
эцэг өвгөд энэ луужинд ан-
хаарлаа хандуулахдаа хойрго
байснаас, (эдүгээ эдгээр зүйл
нь зуурдынх байв) тэд дэг-
жээгүй юм; бүр тэрчлэн
сүнслэг зүйлүүдийн хувьд ч
тийм болой.

44 Учир нь болгоогтун, мөн-
хийн жаргалд хүрэх шулуун
замыг та нарт заах Христийн
“үгэнд анхаарлаа хандуулах
нь амлагдсан нутагт хүрэх
шулуун замыг тэдэнд заах уг
луужинд эцэг өвгөд маань
анхаарлаа хандуулахад байс-
ны адил амархан болой.

45 Мөн эдүгээ би хэлнэ, энэ
зүйлд хэв шинж үгүй гэж үү?
Учир нь үүний чигийг дагас-
наар, бидний эцэг өвгөдийг
амлагдсан нутагт энэ чиглүү-
лэгч авчирсан нь гарцаагүйн
адил, хэрэв бид тэдгээрийн
чигийг нь дагавал Христийн
үгс биднийг энэ харамслын
хөндийн цаад талын илүү
дээр амлалтын нутагт аваа-
чих болно.

46 Ай хүү минь, уг “замын
амархны учир “хойргошихгүй
байцгаая; учир нь бидний

38a 1 Ниф. 16:10; 18:12;

С ба Г 17:1.

40a 1 Ниф. 16:28.

41a Алма 37:6–7.

44a Дуул. 119:105;

1 Ниф. 11:25;

Хил. 3:29–30.

46a Иохан 14:5–6;

2 Ниф. 9:41;

31:17–21;

С ба Г 132:22, 25.

б 1 Ниф. 17:40–41.

эцэг өвгөдөд ийм байлаа; учир нь, хэрэв тэд харсан бол тэд “амьдарч болохуйцаар тэдэнд бэлтгэгдсэн байв; бүр энэ нь бидний хувьд ч ийм билээ. Зам нь бэлтгэгдсэн, мөн хэрэв бид харвал бид үүрд амьдарч болох болно.

47 Мөн эдүгээ, хүү минь, чи эдгээр ариун нандин зүйлүүдэд санаа тавихыг мэд, тийм ээ, чи Бурханд найдан амьдрахаа мэдтүгэй. Энэ хүмүүст оч мөн үгийг тунхагла, мөн чанд бай. Хүү минь, сайныг ерөөе.

Хүү Шиблондоо өгсөн Алмагийн зарлигууд оршвой.

38 дугаар бүлэгт агуулагдав.

БҮЛЭГ 38

Шиблон зөв шударгын төлөө хавчигдав—Дэлхийн амь мөн гэрэл болох Христэд аврал байдаг—Бүхий л дур хүслээ хазаарла. Ойролцоогоор мээ 74 он.

Хүү минь, миний үгсэд чих тавь, учир нь би чамд хэлнэ, бүр Хиламанд хэлсний адил, та нар Бурханы зарлигуудыг дагахын хэрээр та нар уг нутагт дэгжих болно; мөн та нар Бурханы зарлигуудыг дагахгүй байхынхаа хэрээр та нар түүний дэргэдээс тусгаарлагдах болно.

2 Мөн эдүгээ, хүү минь, чиний гуйвшгүй байдал мөн Бурханд итгэх итгэлийн чинь төлөө би чиний учир маш ихээр баясна гэдэгтээ найдаж байна; учир нь чи залуудаа Их Эзэн Бурхандаа хандаж эхэлсэн шигээ, тэрчлэн би чамайг түүний зарлигийг дагахаа “үргэлжлүүлнэ хэмээн найддаг; учир нь эцсээ хүртэл ⁶тэвчих тэр нь адислагдах болно.

3 Би чамд хэлнэ, хүү минь, би аль хэдийн чамд маш ихээр баярласан, учир нь “зорамчуудын хүмүүсийн дундах чиний итгэлтэй байдал мөн чиний хичээнгүй чанар, мөн чиний тэвчээр мөн чиний удаан хугацааны тэсвэрийн учир буюу.

4 Учир нь чамайг хүлүүлсэн байсныг би мэднэ; тийм ээ, мөн түүнчлэн чи үгийн төлөө чулуугаар шидүүлснийг би мэднэ; мөн Их Эзэн “чамтай хамт байсан учир чи энэ бүгдийг ⁶тэвчээртэйгээр хүлцсэн; мөн эдүгээ Их Эзэн чамайг чөлөөлснийг чи мэднэ.

5 Мөн эдүгээ Шиблон, хүү минь, чи Бурханд “найдлага тавихын хэрээр өөрийн бэрхшээл, мөн ⁶зүдгүүр, мөн зовлонгуудаасаа “ангижруулагдаж мөн эцсийн өдөр өргөгдөх болно гэдгийг чамайг санаасай хэмээнэ би.

46в Иохан 11:25;

Хил. 8:15;

3 Ниф. 15:9.

38 2а Алма 63:1–2.

б 2 Ниф. 31:15–20;

3 Ниф. 15:9; 27:6,
16–17.

3а Алма 31:7.

4а Ром 8:35–39.

б су Тэвчээр.

5а Алма 36:27.

су Итгэл.

б С ба Г 3:8; 121:7–8.

в Мат. 11:28–30.

6 Эдүгээ, хүү минь, эдгээр зүйлийг би өөрийнхөөрөө мэддэг хэмээн би чамайг бүү бодоосой гэнэ, харин эдгээр зүйлийг надад мэдүүлдэг нь надад орших Бурханы Сүнс юм; учир нь хэрэв би Бурханаар “төрөөгүйсэн бол би эдгээр зүйлийг мэдэхгүй байх байсан.

7 Гэвч болгоогтун, Их Эзэн өөрийн агуу нигүүлсэлдээ өөрийн хүмүүсийн дундах “устгалын ажлыг би зогсоох ёстой хэмээн надад тунхаглуулахаар ⁶тэнгэр элчээ илгээсэн юм; тийм ээ, мөн би тэнгэр элчийг нүүр тулан харж, мөн тэрээр надтай ярьсан, мөн түүний дуу хоолой аянга мэт байж, мөн энэ нь бүх газрыг доргиосон бөлгөө.

8 Мөнхүү улиран тохиох дор би гурван өдөр мөн гурван шөнө бодгалийн хамгийн зовиуртай өвдөлт хийгээд шаналалд байв; мөн хэзээ ч, би Их Эзэн Есүс Христэд нигүүлслийн тул залбиран гуйх хүртлээ, би нүглүүдийнхээ “ангжралыг хүлээн аваагүй билээ. Гэвч болгоогтун, би түүнээс залбиран гуйж тэгээд өөрийн бодгальд амгаланг олсон билээ.

9 Мөн эдүгээ, хүү минь, чи мэргэн ухаанд суралцаж болно хэмээн, чи зөвхөн Христэд мөн түүгээр бус аваас хүмүүн

аврагдаж чадах “өөр зам эсвээс арга үгүй гэдгийг надаас суралцаж болохын тул би үүнийг чамд хэлэв. Болгоогтун, тэр бол ⁶дэлхийн амь мөн гэрэл билээ. Болгоогтун, тэр бол үнэн хийгээд зөв шударгын үг билээ.

10 Мөн эдүгээ, чи үгийг зааж эхэлсэн шигээ, тэрчлэн би чамайг үргэлжлүүлэн заагаасай хэмээнэ; мөн чамайг бүх зүйлд хичээнгүй мөн өөрийгөө захирах чадвартай байгаасай хэмээнэ би.

11 Бардамналд хөөрөхгүйгээ мэд; тийм ээ, өөрийн мэргэн ухаанд, бас өөрийн их хүчээр “сагсуурахгүй байхаа мэд.

12 Зоригийг хэрэглэ, гэвч бүү дээрэлх; мөн түүнчлэн чи хайраар дүүргэгдэж болохын тулд бүх хүслээ хазаарлахыг мэдээрэй; чи залхаг байдлаас татгалзахыг мэдээрэй.

13 Зорамчуудын адил бүү залбир, учир нь тэд хүмүүнд сонсгохоор мөн өөрсдийн мэргэн ухааныг магтуулахаар залбирдгийг чи харсан болой.

14 Ай Бурхан, бид ах дүүсээсээ “илүү учир танд би талархъя гэж бүү хэл; харин: Ай Их Эзэн, миний зохисгүйг өршөө, мөн ах дүүсийг минь нигүүлслээрээ санаач хэмээн хэл — тийм ээ, Бурханы өмнө ⁶зохисгүй байдлаа цаг үргэлж хүлээж бай.

15 Мөн Их Эзэн бодгалийг

6a Алма 36:26;
С ба Г 5:16.
су Дахин төрөх,
Бурханаас төрөх.
7a Алма 26:17–18;

36:6–11.
б Мозая 27:11–17.
8a су Нүглүүдийн
ангжрал.
9a Хил. 5:9.

б Мозая 16:9.
11a су Бардамнал.
14a Алма 31:16.
б Лук 18:10–14.

чинь адисалж мөн амгалан суулгахаар чамайг өөрийн хаант улсад эцсийн өдөр хүлээн авах болтугай. Эдүгээ явагтун, хүү минь, мөн үгийг энэ хүмүүст заагтун. Чанд байгтун. Хүү минь, сайныг ерөөе.

Хүү Кориантондоо өгсөн Алмагийн зарлигууд оршвой.

39-өөс 42 дугаар бүлэгт агуулагдав.

БҮЛЭГ 39

Хурьцлын нүгэл нь жигшүүрт хэрэг мөн — Кориантоны нүглүүд үгийг хүлээн авахаас зорамчуудыг түдгэлзүүлэв — Христийн гэтэлгэл бол үүнээс урьдах тэднийг ч итгэлээр нь аврахад хүчинтэй. Ойролцоогоор мээ 74 он.

Мөн эдүгээ, хүү минь, ахад чинь хэлснээс өөр хэлэх зарим нэгэн зүйл надад байна; учир нь болгоогтун, Бурханы зарлигуудыг дагах ахынхаа тууштай байдал, түүний итгэл дүүрэн байдал, мөн түүний хичээнгүй чанарыг чи анхаараагүй гэж үү? Болгоогтун, тэр чамд сайн үлгэр жишээ үзүүлээгүй гэж үү?

2 Учир нь чи ахынхтайгаа адил тийм их анхаарлыг, “Зорамын хүмүүсийн дунд

миний үгсэд хандуулаагүй. Эдүгээ энэ бол чамайг шүүмжлэх миний зүйл; чи өөрийн хүч мөн өөрийн мэргэн ухаанд сагсуурч байсан болой.

3 Мөн энэ нь бүгд бус, хүү минь. Чи надад харамсалтай болох түүнийг хийсэн; учир нь чи тохинууллыг орхиж, мөн леменчүүдийн хилийн ойролцоох Широны нутаг тийш “янхан эм Изабелын араас одсон шүү дээ.

4 Тийм ээ, тэр эмэгтэй олон эрийн зүрх сэтгэлийг “хулгайлсан, гэвч энэ нь шалтаг биш юм, хүү минь. Чи өөрт даатгагдан хүлээлгэсэн тэр тохинууллыг анхаарах ёстой байсан.

5 Хүү минь, Их Эзэний мэлмийд “эдгээр зүйл жигшүүрт хэрэг гэдгийг; тийм ээ, гэмгүй цусыг урсгах эсвээс Ариун Сүнснийг үгүйсгэхээс бусад бүх нүглүүдээс хамгийн жигшүүрт зүйл болохыг чи мэдэхгүй гэж үү?

6 Учир нь болгоогтун, хэрэв чамд нэгэнтээ оршиж байсан, мөн чи үүнийг мэдэх атал Ариун Сүнснийг чи “үгүйсгэх аваас, болгоогтун, энэ бол “уучлагдашгүй нүгэл мөн; тийм ээ, мөн Бурханы гэрэл болон мэдлэгийн эсрэг аллага хийдэг хэн боловч, “өршөөлийг хүртэх нь амар бус байна; тийм ээ, хүү минь,

39 2a Алма 38:3.

3a су Тачаангуй,
Тачаангуй байдал.

4a Сур. үгс 7:6–27.

5a су Бэлгийн

харилцааны ёс
суртахуунгүй
байдал.

6a С ба Г 76:35–36.

б су Уучлагдашгүй

нүгэл.

в С ба Г 64:10.
су Уучлах.

өршөөлийг хүртэх нь түүнд амар бус байна гэдгийг би чамд хэлнэ.

7 Мөн эдүгээ, хүү минь, ийм агуу “гэмт үйлд чамайг буруугүй байсан болоосой хэмээн би Бурханд хандана. Хэрэв энэ нь чиний тусын тулд байгаагүй сэн бол, би гэмт үйлүүдийг чинь нуршин, сэтгэлийг чинь шаналгахгүй сэн.

8 Гэвч болгоогтун, чи өөрийн гэмт үйлүүдийг Бурханаас нууж чадахгүй; мөн чи наманчлахгүй аваас тэдгээр нь эцсийн өдөр чиний эсрэг гэрчлэл болон босох болно.

9 Эдүгээ хүү минь, би чамайг наманчлаасай мөн нүглүүдээ орхиосой, мөн нүдээрээ “шунасныхаа араас дахин бүү яваасай, харин эдгээр бүх зүйлийг өөртөө ^бхориглоосой хэмээнэ; учир нь чи үүнийг хийхгүйгээр Бурханы хаант улсыг өвлөх аргагүй. Ай санагтун, үүнийг өөр дээрээ авч, мөн эдгээр зүйлд өөртөө хориг тавь.

10 Мөн би зорьсон үйлүүдийнхээ талаар ах нартайгаа зөвлөхийг өөртөө хүлээхийг чамд зарлиг болгож байна; учир нь болгоогтун, чи залуугаараа байна, мөн чамд ах нараараа залуулж заалгаж байх хэрэгцээ бий. Мөн тэдний зөвлөгөөг анхаарагтун.

11 Өөрийгөө ямар нэг хоосон эсвэл мунхаг зүйлд удирдуу-

лахыг бүү тэвч; чөтгөр зүрх сэтгэлийг чинь тэдгээр ёс бус янхан эмсийн хойноос дахин зайцуулан удирдахыг бүү тэвч. Болгоогтун, ай хүү минь, “зорамчуудын дээр чи ямар их алдсыг авчирсан билээ; учир нь тэд чиний ^ббиеэ авч явахыг хараад миний үгсэд итгэхгүй байсан буйза.

12 Мөн эдүгээ Их Эзэний Сүнс надад хэлж байна: Хүүхдүүддээ сайныг хийхийг “зарлигла, эс тэгвээс тэд олон хүмүүний зүрх сэтгэлийг устгал уруу удирдахвий; тиймийн тул, хүү минь, Бурханаас эмээх айдаст, чи алдсуудаасаа түдгэлзэх ёстойг би чамд зарлиглана;

13 Чи өөрийн бүх оюун, хүч мөн чадлаараа Их Эзэнд хандахыг; чи өөр хэний ч зүрх сэтгэлийг дахин ёс бусыг үйлдэхэд дагуулахгүй байхыг; харин үүний оронд тэдэнд эргэн очиж, мөн өөрийн алдаанууд хийгээд өөрийн үйлдсэн бурууг “хүлээхийг буюу.

14 Баялгийг болон энэ дэлхийн хоосон зүйлсийг бүү “эрэлхийл; учир нь болгоогтун, чи тэдгээрийг өөртэйгээ аваад явж чадахгүй.

15 Мөн эдүгээ, хүү минь, би чамд Христийн ирэлтийн талаар зарим нэгийг хэлэхийг хүснэ. Болгоогтун, би чамд хэлнэ, дэлхийн нүглүүдийг зайлуулан авахаар гарцаагүй

7а су Гэм.

9а су Тачаангуй,
Зуурдын.

б 3 Ниф. 12:30.

11а Алма 35:2–14.

б Ром 2:21–23; 14:13;

Алма 4:11.

12а су Бурханы
зарлигууд; Заах,
Багш.

13а Мозая 27:34–35.

14а Мат. 6:25–34;

Иаков 2:18–19;

С ба Г 6:6–7; 68:31–32.

ирэх нь тэр юм; тийм ээ, тэр өөрийн хүмүүст авралын баярт мэдээг тунхаглахаар ирэх бөлгөө.

16 Мөн эдүгээ, хүү минь, эдгээр баярт мэдээг энэ хүмүүст тунхаглахаар, тэдний оюуныг бэлтгэхээр чиний дуудагдсан тохинуулал энэ байв; өөрөөр хэлбэл тэдний дээр аврал ирж болохын тулд, тэд “хүүхдүүдийнхээ оюуныг түүний ирэлтийн үед үгийг сонгоход бэлтгэж болохын тулд буюу.

17 Мөн эдүгээ би үүний тухайд чиний санааг амраая. Болгоогтун, чи эдгээр зүйл яагаад ийм эртнээс мэдэгдэх ёстойд гайхаж буй. Болгоогтун, би чамд хэлнэ, Бурханд энэ үеийн бодгаль түүний ирэлтийн үед байх бодгалийн адил эрхэм бус уу?

18 Гэтэлгэлийн төлөвлөгөө энэ хүмүүст мэдүүлэгдэх нь тэдний хүүхдүүдэд мэдүүлэгдсэн байхтай нэгэн адил зайлшгүй бус уу?

19 Энэ цагт Их Эзэн эдгээр баярт мэдээг тунхаглуулахаар тэнгэр элчээ хүүхдүүдэд минь илгээхийн адил, өөрөөр хэлбэл түүний ирэлтийн дараах үеийн адил бидэнд ч илгээх нь амархан бус гэж үү?

БҮЛЭГ 40

Христ бүх хүмүүний амилуу-

лалтыг улируулан авчирна—Өөрсдийн амилуулалтын өдрийг хүлээхээр зөв шударгаар үхэгсэд диваажинд мөн ёс бусыг үйлдэгчид гадаад харанхуйд очдог—Бүх зүйл Амилуулалтанд өөрсдийн зохих мөн төгс хэлбэрээрээ сэргээгдэх болно. Ойролцоогоор мээ 74 он.

Эдүгээ хүү минь, чамд миний нэмж хэлэх зүйл энэ байна; учир нь оюун чинь нас барагсдын амилуулалтын талаар зовниж буйг би ухаарч байна.

2 Болгоогтун, би чамд хэлнэ, ямар ч амилуулалт—эсвээс, өөрөөр хэлбэл, энэ зуурдын байдал “үхэшгүй байдалд, энэ ялзрал ялзаршгүй байдалд” тавигдах нь—Христийн ирэлтийн “дарааг хүртэл байхгүйг би хэлэх сэн.

3 Болгоогтун, тэрээр нас барагсдын “амилуулалтыг улируулан авчирдаг. Гэвч болгоогтун, хүү минь, амилуулалт одоохондоо болоогүй. Эдүгээ, би чамд нэг нууцыг задалъя; гэсэн хэдий ч Бурханаас өөрөөс нь бусад хэн ч үл мэдэх “хадгалагдсан олон” нууц байдаг. Гэвч би мэдэж болохын тулд Бурханаас хичээнгүйлэн лавласан нэг зүйлийг чамд үзүүлье—амилуулалтын талаар буюу.

4 Болгоогтун, бүгд нас барагсдаас “ирэх цаг товлогдсон буй. Эдүгээ энэ цаг хэзээ

16а су Гэр бүл—Эцэг эхийн хариуцлага.
40 2а Мозай 16:10–13.
су Мөнх бус, Мөнх

бус байдал.
б 1 Кор. 15:53–54.
в 1 Кор. 15:20.
3а су Амилуулалт.

б С ба Г 25:4; 124:41.
в су Бурханы нууцууд.
4а Иохан 5:28–29.

ирэхийг хэн ч мэдэхгүй; харин Бурхан товлогдсон тэр цагийг мэддэг.

5 Эдүгээ, хүмүүн нь нас барагсдаас ирэх нэг дэх удаад, эсвэл “хоёр дахь удаад, эсвэл гурав дахь удаад байх эсэх нь үл хамаарах болно; учир нь Бурхан эдгээр бүх зүйлийг ⁶мэддэг; мөн энэ нь тохиохыг — үхэгсдээс бүгд босох цаг товлогдсоныг мэдсэн нь надад хангалттай.

6 Эдүгээ үхэх цаг мөн амилуулалтын цагийн хооронд хэсэг хугацаа байх нь зайлшгүй.

7 Мөн эдүгээ энэ үхэх цагаас амилуулалтын тогтоогдсон цагийг хүртэл “хүмүүний сүнс яахыг би лавлах уу?

8 Эдүгээ хүмүүн босох нэгээс олон ээлж товлогдсон эсэх нь хамаагүй; учир нь бүгд нэг дор үхэхгүй, мөн энэ нь хамаагүй; бүгд Бурханы хувьд нэг өдөр мэт байж, мөн тэрхүү цаг нь зөвхөн хүмүүний хувьд хэмжигдсэн байдаг.

9 Тиймийн тул, нас барагсдаас босох тэр цаг нь хүмүүнд товлогдсон ажгуу; мөн үхлийн хийгээд амилуулалтын цагийн хооронд хугацаа буй. Мөн эдүгээ, энэ хугацааны талаар, хүмүүний сүнсэнд юу тохиолдох вэ гэдэг нь миний мэдэж авахаар Их Эзэнээс хичээнгүйлэн лавласан тэр

зүйл билээ; мөн энэ нь миний мэддэг тэр зүйл бөлгөө.

10 Мөн бүгд босох тэр цаг ирэхэд, хүмүүнд товлосон бүх “цагуудыг Бурхан мэддэгийг тэд мэдэх болно.

11 Эдүгээ, “үхэл хийгээд амилуулалтын хоорондох сүнсний байдлын талаар—Болгоогтун, бүх хүмүүний сүнс энэ зуурдын биеийг орхимогцоо, тийм ээ, бүх хүмүүний сүнс, сайн эсвэл муу байлаа ч өөрсдөд нь амьдралыг өгсөн Бурханд, ⁶гэртээ аваачигддаг нь надад нэгэн тэнгэр элчээр мэдүүлэгдсэн билээ.

12 Мөнхүү тэгээд улиран тохиох дор, зөв шударга тэдний сүнс тэд өөрсдийн бүх бэрхшээлүүд мөн санаа зоволт хийгээд харамслаасаа амрах “диваажин гэж нэрлэгдсэн ⁶аз жаргалын байдал, ⁶амар амгалангийн байдал, “энхийн байдалд хүлээн авагдах болно.

13 Мөн тэгээд улиран тохиох дор, ёс бусыг үйлдэгчдийн, тийм ээ, хилэнцэт тэдний сүнснүүдэд—учир нь болгоогтун, Их Эзэний Сүнсний ямар ч хэсэг эсвээс хувь тэндэнд үгүй билээ; учир нь болгоогтун, тэд сайнаас илүүтэйгээр хилэнцэт үйлийг сонгосон бөлгөө; тиймийн тул чөтгөрийн сүнс тэндэнд орж, мөн тэдний гэрийг эзэмшилдээ авсан юм—мөн эдгээр

5а Мозая 26:24–25;
С ба Г 43:18; 76:85.
б су Бурхан, Бурхан тэргүүтэн.
7а Алма 40:21;
С ба Г 138.

су Бие.
10а Үйлс 17:26.
11а Лук 16:22–26;
1 Петр 3:18–19; 4:6;
С ба Г 76:71–74; 138.
б Ном. үгс 12:7;

2 Ниф. 9:38.
12а су Диваажин.
б су Баяр баясгалан.
в су Амрах.
с С ба Г 45:46.
су Амар амгалан.

нь гадаад “харанхуйд хаягдах болно; ⁶уйлаан, мөн гаслан, мөн шүдээ хавирах нь байх болно, мөн энэ нь чөтгөрийн тааллаар боолчлогдсон учир өөрсдийнх нь алдсаас болой.

14 Эдүгээ энэ бол “ёс бусыг үйлдэгчдийн сүнсний байдал болой, тийм ээ, харанхуйд, мөн тэдний дээр ирэх Бурханы уур болох галт хилэнг ⁶айн харуулдахын аймшигт байдалд буюу; тийн тэд энэ “байдалд, түүнчлэн зөв шударгыг үйлдэгчид диваажинд, өөрсдийн амилуулалтын цагийг хүртэл үлдэнэ.

15 Эдүгээ, амилуулалтын өмнөх энэ аз жаргалын байдал мөн сүнсний зовлонгийн байдлыг эхний нэгэн амилуулалт хэмээн ойлгосон зарим нь бий. Тийм ээ, би энэ нь нэгэн амилуулалт хэмээн нэрлэгдэж болохыг хүлээн зөвшөөрнө, сүнс эсвээс бодгалийн босгогдох нь мөн тэдний аз жаргалд эсвэл зовлонд хуваарилагдах нь, яригдсан үгсийн дагуу болой.

16 Мөн болгоогтун, “эхний ⁶амилуулалт гэж буй хэмээн түүнчлэн яригдсан, Христийн үхлээс амилах хүртэл байсан мөн байгаа, эсвээс байх тэд бүгдийн амилуулалт буюу.

17 Эдүгээ, ийм маягаар яригдсан эхний амилуулалт нь сүнснүүдийн амилуулалт

мөн тэднийг аз жаргал эсвэл зовлонд нь “хуваарилагдах явдал хэмээн бид боддоггүй. Энэ нь ийм утгатай хэмээн чи бодож болохгүй.

18 Болгоогтун, би чамд хэлнэ, Үгүй; харин энэ нь Адамын өдрүүдээс Христийн “амилалтыг хүртэлх тэдний сүнс биетэйгээ буцаж нэгдэх гэсэн утгатай юм.

19 Эдүгээ, зөв шударгыг үйлдэгчдийн нэгэн адил ёс бусыг үйлдэгчдийнх ч гэсэн яригдсан тэдний сүнс нь биетэйгээ нэгэн зэрэг нэгтгэгдэх эсэхийг би хэлэхгүй; тэд бүгд гарч ирнэ гэж миний хэлэх нь хангалттай байг; эсвээс өөрөөр хэлбэл, тэдний амилуулалт Христийн амилуулалтын дараа үхэх тэдний амилуулалтаас “өмнө улиран тохиох болно.

20 Эдүгээ, хүү минь, тэдний амилуулалт Христийн амилалтын үед тохионо гэж би хэлээгүй; гэвч болгоогтун, би үүнийг өөрийн санаа болгон хэлье, зөв шударгыг үйлдэгчдийн сүнс мөн биес нь Христийн амилалтын үед, мөн түүнийг тэнгэрт “дээшлэхэд дахин нэгтгэгдэх болно.

21 Харин энэ нь түүний амилалтын үед эсвэл дараа нь болох эсэхийг би хэлэхгүй; харин өдий хэрийг би хэлнэ, үхэл хийгээд биеийн амилуу-

13а су Там.

б Мат. 8:12;

Мозая 16:2.

14а С ба Г 138:20.

б Иаков 6:13;

Мосе 7:1.

в Алма 34:34.

16а Иаков 4:11;

Мозая 15:21–23.

б су Амилуулалт.

17а С ба Г 76:17, 32, 50–51.

18а Мат. 27:52–53.

19а Мозая 15:26.

20а су Дээшлэн одолт.

лалтын хооронд “хугацаа буй, мөн нас барагсад босч ирнэ, мөн сүнс болон бие аль аль нь дахин нэгтгэгдэх болно, мөн Бурханы өмнө зогсохоор ^бавчрагдан, мөн хийснийхээ дагуу шүүгдэх Бурханаас товлондсон тэр цагийг хүртэл сүнсний байдал ^ааз жаргалд эсвэл ^взовлонд байна.

22 Тийм ээ, энэ нь бошиглогчдын амаар яригдсан тэдгээр зүйлүүдийн сэргээлтийг тохиолдуулах болно.

23 “Сүнс нь ^ббиедээ, мөн бие нь сүнсэндээ ^асэргээгдэх болно; тийм ээ, мөн үе болон мөч болгон биедээ сэргээгдэх болно; тийм ээ, бүр толгойноос нэг ч үс гээгдэхгүй; харин бүх зүйл өөрсдийн зохих мөн төгс хэлбэртээ сэргээгдэх болно.

24 Мөн эдүгээ, хүү минь, энэ бол бошиглогчдын амаар “яригдсан тэрхүү сэргээлт юм —

25 Мөн тэгээд зөв шударгыг үйлдэгсэд Бурханы хаант улсад туяарах болно.

26 Гэвч болгоогтун, аймшигт “үхэл ёс бусыг үйлдэгсдийн дээр ирнэ; учир нь тэд зөв шударгад хамаарах зүйлүүдийн хувьд үхмэл юм; учир нь тэд цэвэр бус, мөн ямар ч ^бцэвэр бус зүйл Бурханы хаант улсыг өвлөж авч чадахгүй; харин тэд зайлуулагдаж, мөн хилэнцэт асан

өөрсдийн үйлүүдийн эсвээс өөрсдийн хийсэн ажлуудын үр жимсийг хүртэхээр хуваарилагдах болно; мөн тэд нэгэн гашуун аяганы шаарыг нь ч шавхан ууна.

БҮЛЭГ 41

Амилуулалтанд хүмүүн төгсгөлгүй аз жаргал эсвээс төгсгөлгүй зовлонгийн байдалд ирнэ — Ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй — Эгэл хүмүүн дэлхийд Бурхангүйгээр байдаг — Хувь хүн болгон зуурдын амьдралд олж авсан зан чанар хийгээд ааш авирыг сэргээлтээр буцаан авах болно. Ойролцоогоор мээ 74 он.

Мөн эдүгээ, хүү минь, яригдсан сэргээлтийн талаар хэлэх зүйл надад байна; учир нь болгоогтун, зарим нь судруудыг “гуйвуулсан, мөн энэ зүйлийн учир хол ^бтөөрөн одсон бөлгөө. Мөн чиний санаа түүнчлэн энэ зүйлийн талаар зовнисоор буйг би ухаарч байна. Гэвч болгоогтун, би үүнийг чамд тайлбарлах болно.

2 Би чамд хэлнэ, хүү минь, сэргээлтийн төлөвлөгөө Бурханы шударга ёсны дагуу зайлшгүй шаардагддаг; учир нь энэ бол бүх зүйл өөрсдийн зохист ёсоор сэргээгдэх нь зайлшгүй. Болгоогтун, Хрис-

21а Лук 23:39–43.

б су Диваажин.

в су Там.

г Алма 42:23.

23а ө.х. Сүнс.

С ба Г 88:15–17.

су Бие.

б су Бие.

в 2 Ниф. 9:12–13;

Алма 11:40–45.

24а Иса. 26:19.

26а 1 Ниф. 15:33;

Алма 12:16.

б Алма 11:37.

41 1а 2 Петр 1:20; 3:16;

Алма 13:20.

б су Урвалт.

тийн амилалт хийгээд хүчний дагуу хүмүүний сүнс биедээ сэргээгдэх ёстой, мөн “биеийн хэсэг болгон үүндээ сэргээгдэх нь зайлшгүй мөн шударга болой.

3 Мөн хүмүүн өөрсдийн “ажлуудын дагуу 6шүүгдэх нь Бурханы “шударга ёсны зайлшгүй шаардлага юм; мөн хэрэв энэ амьдралд тэдний ажлууд сайн байсан, мөн тэдний зүрх сэтгэлийн хүслүүд сайн байсан аваас, тэд түүнчлэн эцсийн өдөр сайн болох түүнд 7сэргээгдэх болно.

4 Мөн хэрэв тэдний ажлууд хилэнцэт аваас тэдгээр нь хилэнц болж өөрсдөд нь “сэргээгдэх болно. Тиймийн тул, бүх зүйл өөрсдийн зохист ёсоор, зүйл бүр өөрийн унаган төрхөндөө сэргээгдэх болно—8зуурдын байдал нь үхэшгүй байдалд, 9ялзрах чанар нь ялзаршгүйд босгогдож—Бурханы хаант улсыг өвлөн төгсгөлгүй 10аз жаргалд, эсвээс чөтгөрийн хаант улсыг өвлөн төгсгөлгүй зовлонд босгогдох нэг нь нэг талд нөгөө нь нөгөө талд байх болно—

5 Өөрийн аз жаргалыг хүссэнийхээ дагуу нэг нь аз жаргалд, эсвээс сайныг хүссэнийхээ дагуу сайнд; мөн нөгөө нь

хилэнцийг хүссэнийхээ дагуу хилэнцэд босгогдоно; учир нь тэр бүхэл өдрийн турш хилэнцийг хийхээр хүссэнчлэн түүнчлэн шөнө ирэхэд тэрээр өөрийн шагнал болгон хилэнцийг авна.

6 Мөн тийн нөгөө талд ч үүний адил бөлгөө. Хэрэв тэр нүглүүдээ наманчилж, мөн өдрүүдийнхээ эцсийг хүртэл зөв шударгыг хүссэн бол, тэрчлэн тэрээр зөв шударгад шагнагдах болно.

7 “Эдгээр нь Их Эзэнээр гэтэлгэгдэх тэд билээ; тийм ээ, эдгээр нь ангижруулагдаж, төгсгөлгүй шөнийн харанхуйгаас чөлөөлөгдөх тэд бөлгөө; мөн тийн тэд босно эсвэл унана; учир нь болгоогтун, тэд сайныг эсвэл мууг хийх эсэхээ 8өөрсдөө шүүх сонгогчид билээ.

8 Эдүгээ, Бурханы тогтоолууд нь “хувиршгүй юм; тиймийн тул, хүссэн хэн боловч түүгээр алхаж мөн аврагдах тэрхүү зам бэлтгэгдсэн билээ.

9 Мөн эдүгээ болгоогтун, хүү минь, чи одоог хүртэл нүгэл үйлдэн аз туршсан, сургаалын хэсгүүд дээр Бурханы эсрэг үйлдэхээр “дахин бүү аз турш.

10 Амилуулалтын талаар яригдсан учир чи нүглээс аз жаргалд сэргээгдэх болно

2a Алма 40:23.

3a су Ажлууд.

б су Хариуцах,
Хариуцлага,
Хариуцлагатай;
Шүүх, Шүүлт.
в су Шударга ёс.

г Хил. 14:31.

4a Алма 42:28.

б 2 Ниф. 9:12–13;
С ба Г 138:17.

су Амилуулалт.

в 1 Кор. 15:51–55.

г су Мөнх амьдрал.

7a С ба Г 76:50–70.

б 2 Ниф. 2:26;

Алма 42:27;

Хил. 14:30.

су Сонгох эрх.

8a С ба Г 1:38.

9a С ба Г 42:23–28.

гэж бүү бод. Болгоогтун, би чамд хэлнэ, “ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй.

11 Мөн эдүгээ, хүү минь, “төрөлхийн чанарт байгаа, бүхий л хүмүүн шаналлын гүн мөн алдсын хүлээсэнд байна өөрөөр миний “эгэл чанарт буй гэж би хэлмээр байна; тэд дэлхийд “Бурхангүй, мөн тэд Бурханы шинж чанарын эсрэг явсан билээ; тиймийн тул, тэд аз жаргалын шинж чанарын урвуу байдалд байдаг.

12 Мөн эдүгээ болгоогтун, сэргээлт гэдэг үгийн утга нь төрөлхийн шинж чанартай зүйлийг авч мөн төрөлхийн бус шинж чанарт үүнийг байрлуулдаг, эсвээс үүний төрөлх шинж чанарын нь эсрэг шинж чанарт үүнийг тавьдаг гэсэн үг үү?

13 Ай, хүү минь, энэ нь нөхцөл бус юм; харин сэргээлт гэдэг үгийн утга нь хилэнцтийн хариуд хилэнцийг, эсвээс эглийн хариуд эглийг, эсвээс чөтгөрийнхийг чөтгөрийнхөд нь — сайн болох түүний хариуд сайныг; зөв шударгыг зөв шударга болох түүний хариуд; шударгыг шударга болох түүний хариуд; нигүүлсэнгүйг нигүүлсэнгүй болох түүний хариуд дахин буцаан авчирдаг бөлгөө.

14 Тиймийн тул, хүү минь, өөрийн ах дүүстээ нигүүлсэн-

гүй байхаа мэд; “шударгаар харьц, зөв шударгаар “шүү, мөн үргэлж “сайныг үйлд; мөн хэрэв чи эдгээр бүх зүйлийг хийвэл чи шагналаа хүлээн авах болно; тийм ээ, чамд “нигүүлсэл буцаан сэргээгдэх болно; чамд шударга ёс бас буцаан сэргээгдэх болно; чамд зөв шударга шүүлт буцаан сэргээгдэх болно; мөн чамд сайн нь буцаан шагнагдах болно.

15 Учир нь чиний гадагш илгээсэн нь чамд буцаж ирнэ, мөн сэргээгдэх болно; тиймийн тул, сэргээлт гэдэг үг нүгэлтнийг илүү бүрэн дүүрнээр буруутгаж, мөн түүнийг огтхон ч үл зөвтгөх бөлгөө.

БҮЛЭГ 42

Зуурдын байдал нь наманчилж мөн Бурханд үйлчлэх боломжийг хүмүүнд олгодог сорилтын цаг юм — Уналт нь биеийн мөн сүнсний үхлийг бүх хүн төрөлхтөний дээр авчирсан бөлгөө — Гэтэлгэл наманчлалаар ирдэг — Бурхан өөрөө дэлхийн нүглийг цагаатгана — Нигүүлсэл нь наманчлах тэдэнд зориулагдсан болой — Бусад бүгд нь Бурханы шударга ёсонд харьяалагдах бөлгөө — Цагаатгалын улмаас нигүүлсэл ирдэг — Зөвхөн үнэнээр гэмшигчид аврагддаг. Ойролцоогоор мээ 74 он.

10a Дуул. 32:10; Иса. 57:20–21; Хил. 13:38.

11a Мозая 3:19.

сү Эгэл хүн.

б сү Тачаангуй,

Зуурдын. в Ефес. 2:12.

14a су Үнэнч, Үнэнч

шударга.

б Иохан 7:24;

С ба Г 11:12.

в С ба Г 6:13; 58:27–28.

г су Нигүүлсэнгүй,

Нигүүлсэл.

Мөн эдүгээ, хүү минь, чиний санааг зовоож буй зарим нэг илүү зүйл байгааг би ухаарч байна, чиний ойлгохгүй байгаа тэр нь—нүгэлтнийг шийтгэхэд Бурханы “шударга ёсны талаар юм; учир нь нүгэлтэн зовлонгийн байдалд хуваарилагдах нь шардга бус хэмээн бодохыг ч оролдож байна.

2 Эдүгээ болгоогтун, хүү минь, би энэ зүйлийг чамд тайлбарлах болно. Учир нь болгоогтун, Их Эзэн Бурхан өөрсдийг нь гарган авсан газрыг хагалуулахаар бидний анхны эцэг эхийг “Еденийн цэцэрлэгээс ^ххөөсний дараа—тийм ээ, тэрээр хүмүүнийг татан гаргаж, мөн тэрээр Еденийн цэцэрлэгийн дорнод талд ^ххерубим, мөн зүг бүрд эргэх галт илдийг, ^аамьдралын модыг хамгаалуулахаар байрлуулжээ—

3 Эдүгээ, хүмүүн Бурханы адил сайн ба мууг мэддэг болсныг бид харав; мөн тэрээр гараа сунган, мөн түүнчлэн амьдралын модноос авч, мөн идээд мөн үүрд амьдрах вий хэмээн, Их Эзэн Бурхан херубимыг мөн галт илдийг, тэрээр уг жимсийг хүртэхгүй байхын тулд байрлуулжээ—

4 Мөн тийн хүмүүнд наманчлах цаг, тийм ээ, “сорил-

тын цаг, наманчлах хийгээд Бурханд үйлчлэх цаг олгогдсоныг бид харав.

5 Учир нь болгоогтун, хэрэв Адам тэр даруй гараа сунган, мөн амьдралын модныхоос хүртсэн бол, Бурханы үгийн дагуу тэр, наманчлах хугацаагүйгээр үүрд амьдрах байсан; тийм ээ, мөн түүнчлэн Бурханы үг хүчингүй болж, мөн авралын агуу төлөвлөгөө бүтэхгүй байсан билээ.

6 Гэвч болгоогтун, “үхэх нь хүмүүнд тохоогдсон юм—тиймийн тул, тэд амьдралын модноос тусгаарлагдсанчлан тэд газрын гадаргуугаас тусгаарлагдах болно—мөн хүмүүн үүрд төөрөлдөж, тийм ээ, тэд ^уунасан хүмүүн болжээ.

7 Мөн эдүгээ, чи үүгээр бидний анхны эцэг эх биеийн хийгээд сүнслэг байдлын аль алинаар нь Их Эзэний дэргэдээс “тусгаарлагдсаныг харав; мөн тийн тэд, өөрсдийн хүсэл ^бтааллын эрхшээлийг дагагчид болсныг бид харав.

8 Эдүгээ болгоогтун, хүмүүн энэ биеийн үхлээс буцаагдах нь зохистой байсангүй, учир нь тэгэх нь “аз жаргалын агуу төлөвлөгөөг устгах байв.

9 Тиймийн тул, сүнс хэзээ ч үхэж болдоггүйн учир, мөн “уналт нь бүх хүн төрөлхтний дээр биеийнхтэй нэгэн адил

42 1а 2 Ниф. 26:7;
Мозая 15:26–27.
су Шударга ёс.
2а су Еден.
б Эхл. 3:23–24;
Моце 4:28–31.
в су Херубим.

г Эхл. 2:9.
4а Алма 34:32–33.
6а су Биеийн үхэл.
б Мозая 16:3–5.
су Адам Ева хоёрын
Уналт.
7а 2 Ниф. 2:5; 9:6;

Хил. 14:16.
су Сүнсний үхэл.
б су Сонгох эрх.
8а Алма 34:9;
Моце 6:62.
9а су Адам Ева хоёрын
Уналт.

сүнсний үхлийг ч авчирсан буюу, тэгснээр тэд Их Эзэний дэргэдээс тусгаарлагдсан билээ, хүн төрөлхтөн энэхүү сүнсний үхлээс буцаагдах шаардлагатай байв.

10 Тиймийн тул, тэд “төрөлхөөсөө ^бэгэл, тачаангуй, чөтгөр мэт болж, энэхүү ^всорилтын байдал нь тэдний хувьд бэлтгэх байдал болсон ажгуу; энэ нь бэлтгэлийн байдал болсон билээ.

11 Мөн эдүгээ санагтун, хүү минь, хэрэв гэтэлгэлийн энэ төлөвлөгөө байгаагүй аваас (үүнийг эс тооцвол) үхсэн даруйдаа тэдний сүнс, Их Эзэний дэргэдээс тусгаарлагдсан учир “зовлонт байх байсан.

12 Мөн эдүгээ, хүмүүн өөрийнхөө дуулгаваргүйн учир өөрийнхөө дээр авчирсан тэрхүү уналтын байдлаас хүмүүсийг буцаах ямар ч арга байхгүй байв;

13 Тиймийн тул, шударга ёсны дагуу, “гэтэлгэлийн төлөвлөгөө нь энэхүү сорилтын байдал тийм ээ, энэ бэлтгэлийн байдал дахь хүмүүний ^бнаманчлалын нөхцөлөөс бусдаар бол үйлчилж чадахгүй; учир нь эдгээр нөхцөлүүдийг хангахаас бусдаар, шударга ёсны ажлыг устгахгүйгээр нигүүлсэл үйлчилж чадахгүй. Эдүгээ шударга ёсны ажил

устгагдах учиргүй; хэрэв тэгвэл, Бурхан нь Бурхан байхаа ^вболих сон.

14 Мөн бүх хүн төрөлхтөн “унасныг, мөн тэд ^бшударга ёсны хяналтан дор байсныг бид ийн харав; тийм ээ, тэднийг үүрд түүний дэргэдээс тусгаарлагдахаар хуваарилагдсан Бурханы шударга ёсных буюу.

15 Мөн эдүгээ, нигүүлслийн төлөвлөгөө нь цагаатгал хийгдэхгүйгээр улиран тохиогдох боломжгүй; тиймийн тул Бурхан нь “төгс, шударга Бурхан, мөн түүнчлэн нигүүлсэнгүй Бурхан байж болохын тулд ^бнигүүлслийн төлөвлөгөөг гүйцэлдүүлэхээр, “шударга ёсны шаардлагыг хангахаар Бурхан өөрөө дэлхийн нүглийн төлөө ‘цагаатгалыг нөхөн төлдөг.

16 Эдүгээ, түүнчлэн сүнсний амьдралын адил “мөнхийн байх аз жаргалын төлөвлөгөөний эсрэг тавигдсан, сүнсний амьдралын адил мөнхийн байх шийтгэлгүй аваас наманчлал ирж чадахгүй.

17 Эдүгээ, “нүгэл үйлддэггүй аваас хүмүүн яаж наманчлах билээ? ^вХууль үгүй бол тэр яаж нүгэл үйлдэж чадах сан билээ? Шийтгэл үгүй бол хууль хэрхэн байж чадах билээ?

10а су Эгэл хүн.
 б су Тачаангуй,
 Зуурдын.
 в су Мөнх бус, Мөнх
 бус байдал.
 11а 2 Ниф. 9:7–9.
 13а су Гэтэлгэлийн
 төлөвлөгөө.

б су Наманчлах,
 Наманчлал.
 в 2 Ниф. 2:13–14.
 14а Алма 22:13–14.
 б 2 Ниф. 2:5.
 15а 3 Ниф. 12:48.
 б су Нигүүлсэнгүй,
 Нигүүлсэл.

в су Шударга ёс.
 з 2 Ниф. 9:7–10;
 Мозая 16:7–8.
 су Цагаатгах,
 Цагаатгал.
 16а С ба Г 19:10–12.
 17а су Нүгэл.
 б Ром 4:15.

18 Эдүгээ, шийтгэл нь тогтоогдсон, мөн хүмүүнд “ухамсрын гэмшлийг авчирсан тэрхүү шударга хууль өгөгдсөн билээ.

19 Эдүгээ, хэрэв хууль өгөгдөөгүй бол—хэрэв хүмүүн “аллага үйлдсэн бол үхэх ёстой хэмээн— тэрээр хэрэв тэр аллага үйлдвэл үхнэ хэмээн айх гэж үү?

20 Мөн түүнчлэн, хэрэв нүглийн эсрэг хууль өгөгдөөгүй сэн бол хүмүүн нь нүгэл үйлдэхээс айхгүй байх сан.

21 Мөн хэрэв “хууль өгөгдөөгүй сэн бол, хэрэв хүмүүн нь нүгэл үйлдсэн бол шударга ёс эсвээс нигүүлсэл юу хийж чадах вэ? Учир нь тэдгээр нь тэр хүний дээр эрхгүй байх болно.

22 Гэвч хууль өгөгдсөн, мөн шийтгэл нь тогтоогдсон, мөн “наманчлал олгогдсон юм; нигүүлсэл нь наманчлалыг шаардана; өөрөөр бол, шударга ёс нь уг хүнийг шаардаж, мөн шударга ёс хуулийг хэрэгжүүлж, мөн хууль нь шийтгэлийг оноодог; хэрвээ тийм бус аваас, шударга ёсны ажлууд устгагдаж, мөн Бурхан нь Бурхан байхаа болих сон.

23 Гэвч Бурхан Бурхан байхаа болихгүй, мөн “нигүүлсэл

нь гэмшигчийг шаарддаг, мөн нигүүлсэл нь ^бцагаатгалын учир ирдэг; мөн цагаатгал нь нас барагсдын ^аамилуулалтыг улируулан тохиолгодог; мөн нас барагсдын амилуулалт нь хүмүүнийг Бурханы дэргэд ^вбуцан авчирдаг; мөн ийн тэд, өөрсдийн хийсний дагуу, хууль болоод шударга ёсны дагуу ^ошүүгдэхийн тулд түүний дэргэд байхаар сэргээгддэг.

24 Учир нь болгоогтун, шударга ёс нь өөрийн бүх шаардлагуудыг гүйцээж, мөн түүнчлэн нигүүлсэл нь өөрийн болох бүгдийг өөртөө харьяалуулдаг; мөн тийн, үнэнээр гэмшигчээс өөр хэн ч аврагдахгүй.

25 Юу, чи нигүүлсэл нь “шударга ёсыг дээрэмдэж болно хэмээн бодно уу? Би чамд хэлнэ, Үгүй; огтхон ч тийм бус. Хэрэв тийм аваас, Бурхан нь Бурхан байхаа болих сон.

26 Мөн тийн Бурхан дэлхийн “үүслээс бэлтгэгдсэн өөрийн тэр агуу их хийгээд мөнхийн ^бзорилгуудыг авчирдаг. Мөн тийн хүмүүний аврал хийгээд гэтэлгэл нь, мөн түүнчлэн тэдний устгал мөн зовлон нь ирдэг.

27 Тиймийн тул, ай хүү минь, ирэх “хэн боловч ирж мөн

18а су Ухамсар.

19а су Аллага.

21а 2 Ниф. 9:25–26;
Мозая 3:11.

22а су Наманчлах,
Наманчлал.

23а су Нигүүлсэнгүй,
Нигүүлсэл.

б су Цагаатгах,

Цагаатгал.

в 2 Ниф. 2:8; 9:4;

Алма 7:12; 11:41–45;
12:24–25;

Хил. 14:15–18;

Морм. 9:13.

г Алма 40:21–24.

д су Эцсийн шүүлт.

25а су Шударга ёс.

26а Алма 13:3;

3 Ниф. 1:14.

б 2 Ниф. 2:14–30;
Моисе 1:39.

27а Алма 5:34;

Хил. 14:30.

су Сонгох эрх.

амьдралын уснаас чөлөөтэй-гөөр хүртэж болно; мөн ирэхгүй хэн боловч мөнхүү тэр нь ирэхээр үл албадуулагддаг; гэвч эцсийн өдөр “хийсний-хээ дагуу түүнд “сэргээгдэх болно.

28 Хэрэв тэр “хилэнц үйлдэхийг хүссэн, мөн өөрийн өдрүүдэд наманчлаагүй аваас, болгоогтун, хилэнц нь Бурханы сэргээлтийн дагуу түүнд хийгдэх болно.

29 Мөн эдүгээ, хүү минь, чамайг эдгээр зүйл дахин бүү зовоогоосой, мөн зөвхөн доош наманчлалд авчрах зовлонгоор нүглүүд чинь чамайг зовоогоосой хэмээн би хүснэ.

30 Ай хүү минь, чамайг Бурханы шударга ёсыг дахин бүү үгүйсгээсэй хэмээн би хүснэ. Бурханы шударга ёсыг үгүйсгээд нүглүүдээ хаацайлахыг огтхон ч бүү хичээ; харин Бурханы шударга ёс, мөн түүний нигүүлсэл хийгээд тэсвэр нь зүрх сэтгэлд чинь бүрэн дүүрнээр нөлөөлөхийг зөвшөөр чи; мөн энэ нь чамайг доош тоос шороо лугаа адил “даруу байдалд авчрахыг зөвшөөр.

31 Мөн эдүгээ, Ай хүү минь, чи энэ хүмүүст үгийг номлохоор Бурханаар дуудагдсан билээ. Мөн эдүгээ, хүү минь, чи өөрийн замаар явж, бодгалиудыг наманчлалд авчирч болохын тулд, нигүүлслийн агуу төлөвлөгөөнд тэд

харьяалагдаж болохын тулд үгийг үнэнээр мөн чандаар тунхагла. Мөн бүр миний үгсийн дагуу Бурхан чамд соёрхох болтугай. Амен.

БҮЛЭГ 43

Алма болон түүний хөвгүүд үгийг номлов—Зорамчууд болон нифайчуудаас тэрслэгчид бусад нь леменчүүд болцоов—Нифайчуудын эсрэг дайтахаар леменчүүд ирэв—Моронай хамгаалалтын хуягаар нифайчуудыг хуяглав—Их Эзэн леменчүүдийн байлдааны бодлогыг Алмад илчлэв—Нифайчууд өөрсдийн гэр орон, эрх чөлөө, гэр бүл, мөн шашнаа хамгаалав—Моронай Лихай нарын их цэрэг леменчүүдийг бүслэв. Ойролцоогоор мээ 74 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Алмагийн хөвгүүд хүмүүсийн дунд Бурханы үгийг тунхаглахаар явцгаав. Мөн Алма, түүнчлэн, өөрөө, амарч үл чадан түүнчлэн явав.

2 Эдүгээ тэд бошиглолын мөн илчлэлтийн суу билгийн дагуу үгийг мөн үнэнийг номлож байсан гэдгээс өөрийг бид тэдний номлолын талаар дахин ярихгүй; мөн тэд өөрсдийн дуудагдсан Бурханы “ариун жаягийн дагуу номлоцгоов.

3 Мөн эдүгээ би шүүгчдийн засаглалын арваннайм дахь онд леменчүүд мөн нифай-

276 Иса. 59:18;
Илч. 20:12.
в Алма 41:15.

28a Алма 41:2–5.
30a су Даруу, Даруу
байдал.

43 2a су Мелкизедек
санваар.

чуудын хооронд болсон дайнуудын шастирт эргэн оръё.

4 Учир нь болгоогтун, улиран тохиох дор “зорамчууд леменчүүд болов; тиймийн тул, арваннайм дахь оны эхэнд леменчүүд тэдний дээр ирж буйг Нифайн хүмүүс харав; тиймийн тул тэд дайны бэлтгэл хийв; тийм ээ, тэд өөрсдийн их цэргийг Жершоны нутагт нэгтгэн цуглуулав.

5 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд мянга мянгаараа ирэв; мөн тэд зорамчуудын газар нутаг болох Антионум нутагт орж ирэв; мөн Зерахемна гэж нэрлэгдэх нэг хүн тэдний удирдагч байв.

6 Мөн эдүгээ амалекайчууд леменчүүдийг бодвол илүү хэрцгий мөн аллагад илүү дур сонирхолтой байв, тиймийн тул Зерахемна леменчүүдийн дээрх ерөнхий ахлагчдыг томилов, мөн тэд бүгдээрээ Амалекайчууд мөн зорамчууд байв.

7 Эдүгээ тэр үүнийг нифайчуудад хандах үзэн ядах үзлийг нь хадгалж болохын тулд, мөн өөрийнхөө санааг гүйцэлдүүлэн тэднийг эрхшээлдээ оруулахаар хийсэн ажгуу.

8 Учир нь болгоогтун түүний санаа нь леменчүүдийг нифайчуудын эсрэг уурлуулахаар өдөөн хатгах явдал байв; мөн ингэснээр тэр тэдний дээр их хүчийг хууль бусаар эзэлж болохын тулд,

мөн нифайчуудыг боолчлолд оруулснаар тэдний дээр хүчийг олж болохын тулд тэрээр үүнийг хийжээ.

9 Мөн эдүгээ дайснуудынхаа гарт орохоос хамгаалж болохын тулд нифайчууд өөрсдийн газар нутаг, өөрсдийн орон байр, өөрсдийн “эхнэр болоод хүүхдүүдийг дэмжих нь тэдний санаа байв; мөн түүнчлэн тэд хүслийнхээ дагуу Бурханыг шүтэн биширч болохын тулд өөрсдийн эрх хийгээд өөрсдийн боломжууд, тийм ээ, мөн түүнчлэн өөрсдийн ⁶эрх чөлөөг хадгалан үлдээж болохын тулд болой.

10 Учир нь хэрвээ тэд леменчүүдийн гарт орох юм бол, үнэн болон амьд Бурханыг, “сүнсээр болон үнэнээр Бурханыг ⁶бишрэн шүтэх хэнийг ч гэсэн леменчүүд устгах болно гэдгийг мэдсэн бөлгөө.

11 Тийм ээ, мөн Аммоны хүмүүс гэж нэрлэгдсэн Антай-Нифай-Лихайн хүмүүс болох “ах дүүсийнхээ эсрэг леменчүүд үлэмжийн үзэн ядалтаар ханддагийг түүнчлэн тэд мэдсэн буюу—мөн Аммоны хүмүүс зэр ээвсгээ агсахгүй, тийм ээ, тэд гэрээнд орсон мөн тэд үүнийгээ зөрчихгүй байв—тиймийн тул, хэрэв тэд леменчүүдийн гарт орвол тэд устгагдах байлаа.

12 Мөн тэд устгагдахыг нифайчууд тэвчихгүй байв;

4а Алма 35:2–14; 52:33.

9а Алма 44:5; 46:12.

б су Эрх чөлөө.

10а су Шүтэн бишрэх.

б Иохан 4:23–24.

11а Алма 24:1–3, 5, 20;

25:1, 13; 27:2, 21–26.

тиймийн тул тэдэнд өвлөх нутгийг тэд өгсөн бөлгөө.

13 Мөн Аммоны хүмүүс өөрсдийнхөө хөрөнгөний ихээхэн хэсгийг их цэргийг нь дэмжихээр нифайчуудад өгсөн байв; мөн тийн нифайчуудаас тэрсэлсэн, амалекайчууд мөн зорамчууд болон Ноагийн санваартнуудын “үр удам болох тэднээс, мөн Лемен мөн Лемүел, бас Иш-мэилийн хөвгүүдээс бүрдсэн Леменчүүдийн эсрэг нифайчууд дангаараа сөрөн зогсохоор албадуулагдав.

14 Эдүгээ тэдний үр удам нифайчуудын адил бараг тийм олон байв; мөн тийн нифайчууд ах дүүстэйгээ цус асгарах хүртэл тулалдах шаардлагатай болсон ажгуу.

15 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн их цэрэг Антионумын газар нутаг дээр цугларсан учир, болгоогтун, нифайчуудын их цэрэг тэдэнтэй Жершоны газар нутаг дээр уулзахаар бэлтгэсэн байв.

16 Эдүгээ нифайчуудын удирдагч өөрөөр хэлбэл нифайчуудын дээр ерөнхий ахлагчаар томилогдсон хүн — эдүгээ ерөнхий ахмад нь нифайчуудын бүх цэргийн удирдлагыг авчээ — мөн түүний нэрийг Моронай гэдэг байв;

17 Мөн Моронай дайнуудынхаа бүх удирдлага мөн засаглалыг авав. Мөн тэр нифайчуудын бүх цэргийн

ерөнхий ахмадаар томилогдохдоо дөнгөж хорин таван настай байв.

18 Мөнхүү улиран тохиох дор тэр Жершоны хил дээр леменчүүдтэй тулгарч, мөн түүний хүмүүс сэлэм, мөн илд, мөн дайны бүх төрлийн зэвсгээр зэвсэглэсэн байв.

19 Мөн леменчүүдийн их цэрэг Нифайн хүмүүсийг эсвээс Моронай, өөрийн хүмүүсийг цээжний хуяг мөн гарын хаалт, тийм ээ, мөн түүнчлэн толгойгоо хамгаалах дуулга өмсгөж, мөн түүнчлэн тэднийг зузаан хувцсаар хувцаслаж бэлтгэснийг хараад —

20 Эдүгээ Зерахемнагийн их цэрэг тийм зүйлээр огт бэлтгэгдээгүй байв; тэдэнд зөвхөн сэлэм, илднүүд, мөн нум, сумнууд, чулуу мөн дүүгүүрүүд нь байв; мөн тэд хэвлийн тус газраасаа унжуулсан арьснаас өөр юмгүй “нүцгэн байв; тийм ээ, зорамчууд мөн амалекайчуудаас бусад нь бүгд нүцгэн байв;

21 Гэвч тэд цээжний хуягтай бас бамбайгаар хуягласангүй — тиймийн тул, тэд тэдний хуяг дуулгынх нь учир, тэдний тоо нифайчуудынхаас илүү олон байсан ч нифайчуудын их цэргээс үлэмж айв.

22 Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор тэд Жершоны хил дээр нифайчуудын эсрэг довтолж зүрхэлсэнгүй; тиймийн тул тэд Мантай нутагт ирж мөн уг нутгийг

эзэмшилдээ авч болохын тулд тэд Антионумын нутгаас гарч аглаг буйд тийш одоод, мөн аглаг буйдын дотор тойрон явж, Сидон голын эх рүү очив; учир нь тэд Моронайн их цэрэг тэдний хааш одсоныг мэднэ хэмээн бодсонгүй ажээ.

23 Гэвч улиран тохиох дор, тэднийг аглаг буйдад одмогц тэдний буудлыг тандуулахаар Моронай туршуулууд илгээсэн байжээ; мөн Моронай түүнчлэн, Алмагийн бошиглолуудын тухай мэдсэн учир, хэдэн эрсийг түүнд илгээж, нифайчуудын “их цэрэг леменчүүдээс өөрсдийгөө хамгаалахын тулд хааш явахыг Их Эзэнээс лавлахыг түүнээс хүсэв.

24 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний үг Алмад ирж, мөн леменчүүдийн их цэрэг аглаг буйдад, тэд Мантай нутагт дайран орж болно хэмээн, тэд уг хүмүүсийн арай дорой хэсэг рүү дайралтыг эхэлж болохын тулд тойрон явж байгааг Моронайн элч нарт Алма мэдээлэв. Мөн тэдгээр элчүүд одож мөн Моронайд мэдээг хүргэв.

25 Эдүгээ Моронай, леменчүүдийн хэсэг уг нутагт ирж мөн хотыг эзэмшилдээ авах вий хэмээн их цэргийнхээ нэг хэсгийг Жершоны нутагт орхиод, цэргийнхээ үлдсэн хэсгийг авч мөн Мантай нутагт жагсан очив.

26 Мөн тэрээр уг нутгийн

тэр хэсгийн бүх хүмүүсийг леменчүүдийн эсрэг тулалдахаар, газар нутгаа мөн улс орноо, эрх хийгээд эрх чөлөөгөө “хамгаалахаар цугларцгаах болгов; тиймийн тул тэд леменчүүдийн ирэх цагт бэлтгэгдсэн байв.

27 Мөнхүү улиран тохиох дор Моронай их цэргээ Сидон голын эргийн ойролцоох, аглаг буйд дахь Сидон голын өрнөд эрэг дээрх тэр хөндийд нуугдах болгов.

28 Мөн Моронай эргэн тойрондоо туршуулуудыг леменчүүдийн буудал хэзээ ирэхийг мэдэж болохын тулд байрлуулав.

29 Мөн эдүгээ, тэд бүх нутаг даяар өөрсдөдөө хаант улсыг байгуулж болохын тулд тэднийг харьяатаа болгон мөн боолчлолд оруулах нь эсвээс ах дүүсээ устгах нь тэдний зорилго, леменчүүдийн зорилго болохыг Моронай мэдсэн учир;

30 Мөн түүнчлэн тэрээр өөрсдийн нутаг, өөрсдийн “эрх чөлөө, мөн өөрсдийн сүмийг хамгаалах нь нифайчуудын цорын ганц хүсэл байсныг мэдсэн учир, тиймийн тул тэрээр зальт аргаар өөрсдийгөө хамгаалах нь нүгэл биш хэмээн бодож; тиймийн тул тэр туршуулуудаасаа леменчүүд аль замаар явах гэж буйг олж мэдсэн бөлгөө.

31 Тиймийн тул тэрээр цэргээ хуваан мөн нэг хэсгийг нь уг хөндийд авчирч, мөн

тэднийг Рипла толгойн дорнодод, мөн урд талд нь нуужээ;

32 Мөн үлдсэнийг нь тэрээр өрнөдөд байх хөндийд, Сидон голын баруун талд, мөн тийн Мантай нутгийн хязгаарыг хүртэл далдалжээ.

33 Мөн тийн тэрээр хүссэнийхээ дагуу их цэргээ байрлуулсан учир, тэр тэдэнтэй тулахаар бэлтгэсэн байв.

34 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд Моронайн цэргийн нэг хэсэг нь нуугдсан нөгөөх толгойн хойд талд ирэв.

35 Мөн леменчүүд Рипла толгойг өнгөрч мөн уг хөндийд орж мөн Сидон голыг гаталж эхэлсэн учир, толгойн урд нуугдаж байсан “Лихай гэгчээр удирдуулсан цэргүүд мөн тэрээр өөрийн цэргийг урагш удирдаж мөн леменчүүдийг дорнодод араар нь ороон бүслэв.

36 Мөнхүү улиран тохиох дор нифайчуудыг тэдний зүг араас нь ирж буйг леменчүүд хармагцаа, тэд эргэж мөн Лихайн цэргүүдтэй тулалдаж эхлэв.

37 Мөн хоёр тал аль аль нь алалдах тулааныг эхлэв. Харин энэ нь леменчүүдийн хувьд илүү айдас төрүүлэм байв. Учир нь нифайчуудын сэлэм мөн илднүүдэд, бараг цохилт болгон нь үхлийг авчрах хүнд цавчилтуудад тэдний “нүцгэн биес өртсөн болой.

38 Нөгөө талаас нь үзвэл

нифайчуудын дунд энд тэнд илдэнд өртөж мөн цус алдсанаас хааяа нэг хүн унав, тэд биенийхээ амин газруудыг халхалсан, өөрөөр хэлбэл илүү амин газрууд нь леменчүүдийн цохилтоос “цээжний хуягаар мөн гарын хаалтаар, мөн дуулгаар халхлагдсан байлаа; мөн тийн нифайчууд леменчүүдийн дунд үхлийг үргэлжлүүлэн тарьж байв.

39 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд, тэдний дундах агуу устгалын учир, бүр тэд Сидон голын зүг зугтаж эхэлтлээ айж эхлэв.

40 Мөн тэд Лихай болон түүний эрчүүдээр мөрдөгдөж байв; мөн тэд Лихайгаар Сидоны ус уруу туугдаж, мөн тэд Сидоны усыг гатлав. Мөн Лихай тэд гатлахгүйн тулд их цэргээ Сидон голын эрэг дээр авч үлдэв.

41 Мөнхүү улиран тохиох дор Моронай мөн түүний их цэрэг уг хөндийд, Сидон голын нөгөө эрэг дээр леменчүүдтэй тулж мөн тэдний дээрээс дайран орж мөн тэднийг алж эхлэв.

42 Мөн леменчүүд тэдний өмнө Мантай нутгийг чиглэн дахин зугтав; мөн тэд Моронайн их цэрэгтэй дахин тулгарав.

43 Эдүгээ энэ нөхцөлд леменчүүд үлэмж улайран тулалджээ; тийм ээ, леменчүүд хэзээ ч ийм агуу хүч хийгээд зоригтойгоор тулалдсан

нь бүр эхлэлээс хүртэл үзэгдсэн нь үгүй болой.

44 Мөн тэд өөрсдийн ерөнхий ахмадууд хийгээд удирдагчид асан “зорамчууд мөн амалкайчуудаар мөн тэдний ерөнхий ахмад эсвээс тэдний ерөнхий удирдагч мөн захирагч асан Зерахемнагаар зоригжуулагдав; тийм ээ, тэд луу лугаа адил тулалдаж, мөн нифайчуудаас олон нь тэдний гарт алагдав; тийм ээ, учир нь толгойн дуулгуудаас нь олныг хоёр хуваан цөм цохиж, мөн тэд цээжний хуягуудаас нь олныг нэвт цоолж, мөн тэдний олных нь гарыг тас цавчжээ; мөн тийн леменчүүд хэрцгий догшин уурандаа цохин байв.

45 Гэсэн хэдий ч нифайчууд зөв шалтгааны улмаас зоригжуулагдав, учир нь тэд эзэрхийллийн хийгээд “эрх мэдлийн төлөө тулалдаагүй, харин гэр орон мөн ^бэрх чөлөөнийхөө, эхнэр хийгээд хүүхдүүдийнхээ төлөө мөн байгаа бүгдийнхээ төлөө, тийм ээ, шүтэн бишрэх эрх мөн сүмийнхээ төлөө тулалдсан юм.

46 Мөн тэд Бурхандаа өргөх ёстой “үүрэг хэмээн бодсон түүнийгээ хийж байв; учир нь Их Эзэн тэдэнд, мөн түүнчлэн тэдний эцэг өвгөдөд, тийн: Та нар ^бэхний болон хоёр дахь өдөөн хатгалгад буруугүй байхын ^вхэрээр, та

нар дайснуудынхаа гарт эрсдэхийг тэвчихгүй байх болно хэмээн хэлсэн ажгуу.

47 Мөн түүнчлэн Их Эзэн хэлсэн нь: Та нар цус урсгах хүртэл ч гэсэн гэр бүлээ хамгаалах болно хэмээжээ. Тиймийн тул энэ шалтгааны учир нифайчууд өөрсдийгөө, мөн гэр бүлээ мөн газар нутгаа, эх орноо, эрхээ, мөн шашин шүтлэгээ “хамгаалахаар леменчүүдтэй тулалдаж байв.

48 Мөнхүү улиран тохиох дор Моронайн эрс леменчүүдийн хэрцгий догшныг мөн уурыг нь үзээд, тэд нугдайн мөн тэднээс зугтахад ойрхон байв. Мөн Моронай тэдний зорилгыг ойлгосон учир, үгийг илгээж мөн тэдний зүрх сэтгэлийг эдгээр бодлоор—тийм ээ, газар нутаг, эрх чөлөөнийх нь, тийм ээ, дарангуйллаас тусгаар байдлын тухай бодлуудаар зоригжуулав.

49 Мөнхүү улиран тохиох дор тэд леменчүүдийг эргэн довтолж, мөн тэд нэгэн дуугаар Их Эзэн Бурхандаа хандан эрх чөлөө мөн дарангуйллаас тусгаар байдлынхаа төлөө “залбиран гуйв.

50 Мөн тэд леменчүүдийн эсрэг хүчтэйгээр зогсож эхлэв; мөн тэд Их Эзэнд эрх чөлөөнийхөө төлөө залбиран гуйсан чухам тэр цагт, леменчүүд тэдний өмнө зугтаж эхлэв; мөн тэд бүр Сидоны усанд хүртэл зугтав.

44a Алма 43:6.

45a Алма 44:5.

б су Эрх чөлөө.

46a су Үүрэг.

б 3 Ниф. 3:21;

С ба Г 98:23–24.

в Алма 48:14;

С ба Г 98:33–36.

47a С ба Г 134:11.

49a Ег. 2:23–25;

Мозая 29:20.

51 Эдүгээ, леменчүүд тоогоор илүү олон, тийм ээ, нифайчуудын тоог хоёр нугалснаас илүү байв; гэсэн хэдий ч тэд туугдаж, үүнийхээ хэрээр тэд уг хөндийд Сидон голын эрэг дээр нэг хэсэгт нэгдэн цуглуулагдав.

52 Тиймийн тул Моронайн их цэрэг тэднийг бүсэлж, тийм ээ, бүр голын хоёр эргээр, учир нь болгоогтун зүүн эрэгт нь Лихайн эрчүүд байв.

53 Тиймийн тул Зерахемна Сидон голын зүүн эрэг дээрх Лихайн эрчүүдийг мөн Сидон голын баруун эрэг дээрх Моронайн их цэргийг, тэд нифайчуудаар бүслэгдсэнээ хараад, тэд айн чочирдов.

54 Эдүгээ Моронай, тэдний айдсыг хараад, өөрийн эрчүүдэд тэдний цусыг урсгахаа зогсоохыг зарлиг болов.

БҮЛЭГ 44

Энхийн хэлэлцээр хийхийг Моронай леменчүүдэд зарлиг болов, эс тэгвээс тэд устгагдах болно—Зерахемна саналыг эсэргүүцэж мөн тулаан үргэлжлэв—Моронайн их цэрэг леменчүүдийг дийлэв. Ойролцоогоор мээ 74–73 он.

Мөнхүү улиран тохиох дор тэд зогсож мөн тэднээс алхам хойш ухарцгаав. Мөн Моронай Зерахемнад: Болгоогтун, Зерахемна, бид хүмүүний цусанд шунасан хүмүүс байхыг “хүсдэггүй. Та нар бидний

гарт байгаагаа мэднэ, гэсэн ч бид та нарыг алахыг хүсэхгүй байна гэж хэлэв.

2 Болгоогтун, бид эзэрхийллийн төлөө та нарын цусыг урсгаж болохын тулд та нарын эсрэг тулалдах гэж ирсэнгүй; бас бид хэнийг ч боолчлолын буулганд оруулахыг хүсэхгүй байна. Гэвч бидний эсрэг ирсэн та нарын чухамхүү шалтгаан нь энэ билээ; тийм ээ, та нар манай шашны учир бидэнд ууртай байна.

3 Гэвч эдүгээ, Их Эзэн бидэнтэй хамт гэдгийг та нар болгоогтун; мөн тэрээр та нарыг бидний гарт оруулсныг та нар болгоогтун. Мөн эдүгээ бидний шашин мөн Христэд итгэх итгэлийн маань учир энэ нь бидэнд хийгдсэн гэдгийг ойлгоосой хэмээнэ би. Мөн эдүгээ та нар бидний энэ итгэлийг устгаж чадахгүйгээ харлаа.

4 Эдүгээ та нар энэ бол Бурханы үнэн шашин гэдгийг харлаа; тийм ээ, бид түүнд, мөн өөрсдийн бишрэл, мөн өөрсдийн шашинд үнэнч байсан цагт, Бурхан биднийг дэмжиж, мөн хамгаалан мөн хадгалан үлдээнэ гэдгийг та нар харлаа; мөн бид зөрчилд унаж мөн сүсэг бишрэлээ үгүйсгэхгүй аваас Их Эзэн хэзээ ч биднийг устгагдахыг тэвчих нь үгүй.

5 Мөн эдүгээ, Зерахемна, та нарыг дийлэх хүчийг олоход бидний гарыг хүчирхэгжүүл-

сэн бүхнээс хүчит Бурханы нэрээр, бид өөрсдийн итгэлээр, шашин шүтлэгээрээ, мөн шүтэн бишрэх “ёсоороо, мөн сүмээрээ, мөн өөрсдийн эхнэр мөн хүүхдүүддээ өгөх ёстой эрхэм нандин дэмжлэгээр, газар нутагт минь мөн улс оронд минь биднийг нэгтгэдэг ⁶эрх чөлөөгөөр; тийм ээ, мөн түүнчлэн бидний бүх аз жаргалын эх үүсвэр болох, Бурханы нандин үгийг хадгалан үлдээснээр; мөн бидэнд хамгийн эрхэм болох тэр бүгдээр би чамд зарлиглаж байна —

6 Тийм ээ, мөн энэ бол бүгд бус; амь насныхаа төлөө та нарт байгаа бүх хүслүүдээр тань, дайны зэр зэвсгээ бидэнд өгөхийг би та нарт зарлиглана, мөн бид та нарын цусыг эрэлхийлэхгүй, харин та нар замаараа явж мөн бидний эсрэг дайтахаар дахин ирэхгүй аваас амийг тань бид хэлтрүүлэх болно.

7 Мөн эдүгээ, хэрэв та нарийнхүү үйлдэхгүй аваас, болгоогтун, та нар бидний гарт байна, мөн та нарыг дайрахыг, мөн та нар бүрмөсөн үгүй болж болохын тул, биед чинь үхлийн шарх учруулахыг би өөрийн хүмүүст тусгах болно; мөн тэгээд бид энэ хүмүүсийн дээр хэн нь хүчтэй байхыг харах болно; тийм ээ, хэн боолчлолд авчрагдахыг бид үзэх болно.

8 Мөн эдүгээ улиран тохиох дор Зерахемна эдгээр хэлс-

нийг нь сонсоод тэрээр урагшилж мөн сэлэм мөн илдээ, бас нумаа Моронайн гарт өгч, мөн түүнд хэлэв: Болгоогтун, бидний дайны зэр зэвсэг энэ байна; бид тэдгээрийг та нарт өгье, гэвч бид мөн түүнчлэн бидний хүүхдүүд зөрчинө гэдгийг мэдсээр байж та нарт “тангараглахыг тэвчихгүй; харин дайны зэр зэвсгийг маань ав, мөн биднийг аглаг буйд тийш зайлан одохыг зөвшөөр; үгүй бол бид илдээ авч үлдээд, мөн мөхөх эсвэл ялан дийлэх болно.

9 Болгоогтун, бид танай сүсэг бишрэлийнхэн бус; биднийг та нарын гарт оруулсан нь Бурхан гэдэгт бид үл итгэнэ; харин та нарыг бидний илднүүдээс хамгаалсан нь та нарын башир арга гэдэгт итгэнэ. Болгоогтун, та нарыг хамгаалсан нь та нарын “цээжний хуяг мөн бамбайнууд чинь юм.

10 Мөн эдүгээ Зерахемна эдгээр үгийг ярьснаа төгсгөл болгоход, Моронай өөрт хүлээн авсан илд мөн дайны зэвсгүүдийг нь Зерахемнад буцааж өгөөд, хэлсэн нь: Болгоогтун, бид зөрчилдөөнийг төгсгөнө.

11 Эдүгээ би ярьсан үгээ буцааж чадахгүй, тиймийн тул Их Эзэн амьдын адил, та нар бидний эсрэг дайтахаар эргэж ирэхгүй гэсэн тангарагтайгаар явахгүй бол та нар явахгүй. Эдүгээ та нар бидний гарт байгаа учир цусыг

5a су Ёслолууд.
6 су Эрх чөлөө.

8a су Тангарар.
9a Алма 43:38.

чинь газарт асгах болно, эсвээс та нар миний санал болгосон нөхцлүүдэд захирагдах болно.

12 Мөн эдүгээ Моронай эдгээр үгийг хэлсний дараа, Зерахемна илдээ буцаан авч, мөн тэрээр Моронайд уурлаж, мөн Моронайг алж болохын тулд урагш ухасхийв; гэвч түүнийг илдээ өргөмөгц, болгоогтун Моронайн цэргүүдээс нэг нь илдийг нь газар унатал цохиж, мөн энэ нь бариулаараа хугарав; мөн түүнчлэн тэрээр Зерахемнаг цохиж ингэснээр түүний хуйхыг тас цавчсанд мөн энэ нь хөсөр унав. Мөн Зерахемна тэдний өмнөөс ухран цэргүүдийнхээ дунд хүрэв.

13 Мөнхүү улиран тохиох дор хажууд нь зогсож байсан, Зерахемнагийн хуйхыг тас цохисон тэр цэрэг, мөнөө хуйхыг үснээс нь барьж газраас аваад, мөн илднийхээ үзүүр дээр тавьж, мөн тэдний зүг сунгаж, чанга дуугаар тэдэнд хэлсэн нь:

14 Та нар ээр зэвсгээ өгч мөн энхийн гэрээтэйгээр явахгүй бол бүр удирдагчийн чинь хуйх болох, энэ хуйх газарт унасанчлан, та нар ч газарт унах болно.

15 Эдүгээ тэд эдгээр үгийг сонсож мөн илдэн дээрх хуйхыг хараад айж балмагдсан нь олон байв; мөн олон нь урагшилж мөн дайны зэвсгүүдээ Моронайн хөлд хаяж, мөн “энхийн гэрээнд оров. Мөн

гэрээнд орсон болгонд аглаг буйд тийш одохыг зөвшөөрөв.

16 Эдүгээ улиран тохиох дор Зерахемна үлэмж ихээр хилэгнэн, мөн тэрээр цэргүүдийнхээ үлдсэнийг нь нифайчуудын эсрэг илүү хүчтэйгээр тэмцэлдүүлэхээр уурлуулахад өдөөн хатгав.

17 Мөн эдүгээ Моронай леменчүүдийн зөрүүдийн учир уурлав; тиймийн тул тэрээр тэдний зүг довтолж мөн тэднийг алахыг өөрийн хүмүүст зарлиглав. Мөнхүү улиран тохиох дор тэд тэднийг алж эхлэв; тийм ээ, мөн леменчүүд илдээрээ бас чадлаараа тэмцэлдэв.

18 Гэвч болгоогтун тэдний нүцгэн арьс мөн тэдний нүцгэн толгой нифайчуудын хурц илдэнд эрсэдсэн байв; тийм ээ болгоогтун тэд цоо хатгагдаж мөн цавчигдав, тийм ээ, мөн нифайчуудын илдний өмнө үлэмж хурдан унаж байв; мөн бүр Моронайн цэргийн бошиглон хэлсэнчлэн тэд хиарч эхлэв.

19 Эдүгээ Зерахемна, тэрээр тэд бараг бүгд устгагдах гэж байгаагаа хараад, Моронайд, хэрэв тэд үлдсэн тэдний амийг хэлтрүүлэх аваас, тэр мөн түүнчлэн түүний хүмүүс хэзээ ч тэдний эсрэг дайтахаар “ирэхгүй хэмээн тэдэнтэй гэрээ хийхийг тэнхээгээрээ хашгирч амлав.

20 Мөнхүү улиран тохиох дор Моронай хүмүүсийн дундах аллагыг болиулахаар болгов.

Мөн тэрээр леменчүүдээс дайны зэвсгийг нь авчээ; мөн тэд түүнтэй энхийн “гэрээ хийснийхээ дараа аглаг буйд тийш одох нь зөвшөөрөгдөв.

21 Эдүгээ үхэгсдийн тоо нь тооны ихийн улмаас тоологдсонгүй; тийм ээ, нифайчуудаас мөн леменчүүдээс аль алинаас нь үхэгсдийн тоо үлэмж их байв.

22 Мөнхүү улиран тохиох дор тэд үхэгсдээ Сидон голын усанд хаяж, мөн тэдгээр нь урсаж тэнгисийн гүнд булшлагдав.

23 Мөн нифайчуудын, өөрөөр хэлбэл Моронайн их цэрэг, эргэж мөн өөрсдийн гэр орон мөн нутагтаа ирэв.

24 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арваннайм дахь он тийн төгсөв. Мөн Нифайн ялтсууд дээр бичигдсэн, Алмагийн цэдэг ийн төгсөв.

Хиламаны өдрүүд дэх Нифайн хүмүүсийн мөн тэдний дайнууд мөн зөрөлдөөнүүдийн шастир, тэрээр өөрийн өдрүүдэд хөтөлсөн тэрхүү, Хиламаны цэдгийн дагуу оршвой.

45-аас 62 дугаар бүлэгт агуулагдав.

БҮЛЭГ 45

Хиламан Алмагийн үгсэд итгэв — Алма нифайчуудын устгалыг

бошиглов — Тэрээр уг нутгийг адисалж мөн зүхэв — Алма бүр Мосегийн адил Сүнсээр дээш аваачигдсан байж магадгүй — Сүмд зөрөлдөөнүүд ихэв. Ойролцоогоор мээ 73 он.

Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор Нифайн хүмүүс үлэмж баясав, учир нь Их Эзэн тэднийг дайснуудынх нь гараас дахин чөлөөлжээ; тиймийн тул тэд Их Эзэн Бурхандаа талархал мэдүүлэв; тийм ээ, мөн тэд ихэд “мацаг барьж мөн ихэд залбирч, мөн үлэмж агуу баяраар тэд Бурханаа шүтэн бишрэв.

2 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арван ес дэх онд, Алма өөрийн хүү Хиламанд ирж мөн түүнд хэлэв: Хадгалагдсан “цэдгүүдийн талаар чамд миний ярьсан тэдгээр үгсэд чи итгэдэг үү?

3 Мөн Хиламан түүнд хэлэв: Тийм ээ, би итгэдэг.

4 Мөн Алма үүнчлэн хэлэв: Ирэх Есүс Христэд чи итгэдэг үү?

5 Мөн тэрээр хэлсэн нь: Тийм ээ, би таны ярьсан бүх үгэнд итгэдэг.

6 Мөн Алма түүнд үүнчлэн хэлэв: Чи миний зарлигуудыг “дагах уу?

7 Мөн тэрээр хэлэв: Тийм ээ, би таны зарлигуудыг бүх сэтгэл зүрхээрээ дагах болно.

8 Тэгэхэд нь Алма түүнд

20a Алма 62:16–17.

45 1a су Мацаг барих, Мацаг барилт.

2a Алма 37:1–5; 50:38.

6a су Бурханы зарлигууд;

Дуулгавартай байх, Дуулгавартай, Дуулгавартай дагах.

хэлэв: Адислагдсан болой чи; мөн Их Эзэн чамайг энэ нутагт “дэгжээх болно.

9 Гэвч болгоогтун, чамд “бошиглох зарим зүйл надад байна; гэвч чамд миний бошиглохыг чи мэдүүлэхгүй; тийм ээ, миний чамд бошиглох нь мэдүүлэгдэх ёсгүй, бүр бошиглол нь гүйцэлдэх хүртэл; тиймийн тул миний хэлэх үгсийг бичигтүн.

10 Мөн үгс нь эдгээр буюу: Болгоогтун, Есүс Христ өөрийгөө тэдэнд үзүүлэх тэр цагаас “дөрвөн зуун жилийн хойно чухам энэ хүмүүс, нифайчууд, ⁶итгэлгүйдээ бууран доройтох болно гэдгийг би өөрт буй илчлэлтийн суу билгийн дагуу ойлгон ухаарч байна.

11 Тийм ээ, мөн тэгээд тэд дайнууд мөн тахлуудыг, тийм ээ, өлсгөлөнгүүд мөн цус урсалтыг, бүр Нифайн хүмүүс бүрмөсөн “үгүй болтол үзэх болно —

12 Тийм ээ, мөн тэд итгэлгүйдээ бууран доройтож мөн харанхуйн мөн “шунаг тачаангуйн ажилд мөн бүх төрлийн алдаст унах учир энэ болой; тийм ээ, би чамд хэлнэ, тэд ийм агуу гэрэл мөн мэдлэгийн эсрэг нүгэл үйлдэх учир, тийм ээ, би чамд хэлнэ, тэр өдрөөс, энэхүү агуу

алдас ирэхээс өмнө дөрөв дэх үеийнхэн бүгд улиран одоогүй байх болно.

13 Мөн тэр агуу өдрийг ирэхэд, болгоогтун одоо тоологдсон тэд өөрөөр хэлбэл эдүгээ Нифайн хүмүүсийн дунд тоологдсон тэдний үр удам, цаашид Нифайн хүмүүсийн дунд “тоологдохгүй тэр цаг тун удахгүй ирэх болно.

14 Харин үлдэх мөн агуу мөн аймшигт өдөр устгагдаагүй хэн боловч, леменчүүдийн дунд “тоологдож мөн тэдэнтэй адил болох болно, Их Эзэний шавь нар гэж нэрлэгдэх цөөн хэдээс бусад нь бүгд; мөн тэднийг леменчүүд ⁶бүрмөсөн үгүй болох хүртэл нь мөрдөн мөшгөх болно. Мөн эдүгээ, алдсын учир, энэ бошиглол гүйцэлдэх болно.

15 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма эдгээр зүйлийг Хиламанд хэлсний дараа тэрээр түүнийг, мөн түүнчлэн өөрийн бусад хөвгүүдийг адислав; мөн түүнчлэн тэр газар дэлхийг зөв “шударгыг үйлдэгсдийн төлөө адислав.

16 Мөн тэрээр хэлсэн нь: Их Эзэн Бурхан ийн хэлэв — Ёс бусыг үйлдэх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс болгонд, тэд боловсорч гүйцэх үед, уг нутаг, тийм ээ, энэ нутаг, устгалдаа хүртэл “зүхэгдэх

8a 1 Ниф. 4:14;
Алма 48:15–16, 25.

9a су Бошиглох,
Бошиглол.

10a 1 Ниф. 12:10–15;
Хил. 13:9;
Морм. 8:6–7.

б су Урвалт;
Итгэлгүй байдал.

11a Жером 1:10;
Морм. 8:2–3, 6–7.

12a су Тачаадах.
13a Хил. 3:16.
14a Моро. 9:24.

б Моро. 1:1–3.
15a Алма 46:10; 62:40.
16a 2 Ниф. 1:7;
Алма 37:31;
Ифер 2:8–12.

болно; мөн миний хэлсэнчлэн энэ нь ийм байх болно; учир нь энэ бол уг нутаг дээрх Бурханы зүхэл мөн ⁶адислал юм, учир нь нүглийг Их Эзэн хамгийн “бага хэмжээгээр байлаа ч гэсэн хүлээн зөвшөөрч чаддаггүй.

17 Мөн эдүгээ Алма эдгээр үгийг хэлээд тэрээр “сүмийг, тийм ээ, тэр цагаас хойш сүсэг бишрэлдээ тууштай зогсох тэд бүгдийг адислав.

18 Мөн Алма үүнийг хийгээд тэрээр Зерахемлагийн нутгаас гарч, Мелекийн нутагт одох мэтээр явсан бөлгөө. Мөнхүү улиран тохиох дор тэрээр хэзээ ч дахин сонсогдсонгүй; түүний үхэл эсвээс оршуулгын тухай бид мэдэх нь үгүй.

19 Болгоогтун, бид үүнийг, тэрээр зөв шударга хүн байсныг мэднэ; мөн бүр Мосе лугаа адил, тэрээр Сүнсээр дээш аваачигдсан, өөрөөр хэлбэл Их Эзэний мутраар “оршуулагдсан гэдэг яриа сүмд тархжээ. Гэвч болгоогтун, Их Эзэн Мосег өөртөө авсан хэмээн судрууд өгүүлдэг; мөн түүнчлэн Алмаг сүнсээр өөртөө хүлээн авсан хэмээн бид боддог; тиймийн тул, энэ шалтгааны учир түүний үхэл мөн оршуулгын талаар бид юу ч мэддэггүй.

20 Мөн эдүгээ улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын

арван ес дэх оны эхэнд, Хиламан тэдэнд үгийг тунхаглахаар хүмүүсийн дунд одов.

21 Учир нь болгоогтун, леменчүүдтэй хийсэн тэдний дайнууд мөн хүмүүсийн дунд байсан олон жижиг зөрөлдөөнүүд хийгээд үймээнүүдийн учир тэдний дунд “Бурханы үг тунхаглагдах нь, тийм ээ, мөн сүм даяар зохицуулалт хийгдэх нь зайлшгүй болов.

22 Тиймийн тул, Хиламан болон түүний ах дүүс бүх нутагт сүмийг дахин тохиуулахаар, тийм ээ, Нифайн хүмүүсээр эзэмшигдсэн тэр бүх нутаг даяарх хот болгонд одов. Мөнхүү улиран тохиох дор тэд бүх сүмүүдийн дээрх санваартнууд болон багш нарыг бүх нутаг даяар томилов.

23 Мөн эдүгээ улиран тохиох дор Хиламан болон түүний ах дүүс сүмүүдийн дээрх санваартнууд хийгээд багш нарыг томилсны дараа тэдний дунд “зөрөлдөөн гарч, мөн тэдний Хиламан болон түүний ах дүүсийн үгсэд анхаарал тавихгүй байв;

24 Харин өөрсдийн агуу “баялгуудын улмаас сэтгэлдээ хөөрсний учир тэд бардам болжээ; тиймийн тул ⁶өөрсдийн нүдэнд тэд баян болж, мөн Бурханы өмнө зөв шударгаар алхуулах тэдний үгсэд анхаарал тавихгүй байлаа.

166 С ба Г 130:21.

в С ба Г 1:31.

17a су Есүс Христийн Сүм.

19a су Зөөгдсөн хүмүүн биес.

21a Алма 31:5.

23a 3 Ниф. 11:28–29.

24a су Баялгууд.

б су Бардамнал.

БҮЛЭГ 46

Амаликая хаан байхаар хуйвалдав—Моронай эрх чөлөөний туг өргөв—Тэр шашнаа хамгаалахад хүмүүсийг уриалав—Үнэнээр итгэгчид Христийнх хэмээн нэрлэгдэв—Иосефынхны үлдэгдэл хадгалагдан үлдэх болно—Амаликая болон тэрслэгчид Нифайн нутаг тийш зугтав—Эрх чөлөөний төлөө хөдөлгөөнийг үл дэмжсэн тэд үхэлд хүргэгдэв. Ойролцоогоор мээ 73–72 он.

Мөнхүү улиран тохиох дор Хиламан мөн түүний ах дүүсийн үгийг дуулаагүй болгон нь бүгд ах дүүсийнхээ эсрэг нэгдэн цугларав.

2 Мөн эдүгээ болгоогтун, тэд үлэмж хилэгнэж, үүнийхээ хэрээр тэднийг хөнөөхөөр шийдсэн байв.

3 Эдүгээ ах дүүсийнхээ эсрэг хилэгнэсэн тэдний удирдагч нь том биетэй мөн хүчирхэг эр байв; мөн түүний нэрийг Амаликая гэдэг байв.

4 Мөн Амаликая хаан болох хүсэлтэй байв; мөн хилэгнэсэн тэдгээр хүмүүс түүнийг хаанаа байгаасай хэмээн хүсэв; мөн тэдний ихэнх хэсэг нь нутгийн “бага эрх мэдэлтэй шүүгчид байв, мөн тэд хүчийг эрэлхийлж байв.

5 Мөн хэрэв тэд түүнийг дэмжиж мөн түүнийг хаанаа болговол тэр тэднийг хүмүүсийн дээрх захирагч болгоно хэмээх Амаликаягийн

зусардалтанд тэд удирдагдсан байв.

6 Тэд сүмийн дээрх дээд санваартнууд байсны учир, Хиламан мөн түүний ах дүүсийн номлолыг үл ойшоон, тийм ээ, сүмийн дээрх тэдний агуу халамжийг үл ойшоон, тэд Амаликаягаар тийн тэрсэлдээнд удирдагдсан болой.

7 Мөн Амаликаягийн зусар үгсэд итгэсэн нь сүмийн дотор олон байв, тиймийн тул тэд бүр сүмээс ч тэрслэв; мөн леменчүүдийг давсан тэдний тэрхүү агуу “ялалт, мөн Их Эзэний мутраар чөлөөлөгдсөний учир тэдэнд тэр агуу баясал байсан хэдий ч, Нифайн хүмүүсийн байдал ийн үлэмж найдваргүй мөн аюултай байв.

8 Хүмүүний үрс Их Эзэн Бурханаа хичнээн “хурдан мартдагийг, тийм ээ, алдсыг үйлдэхэд, мөн хилэнцэт нэгнээр удирдагдахдаа хичнээн хурдныг бид ийн харлаа.

9 Тийм ээ, мөн түүнчлэн нэгэн ихэд ёс бус хүн, хүмүүний үрсийн дунд ямар агуу “ёс бусыг үйлдүүлж чаддагийг бид харлаа.

10 Тийм ээ, Амаликаяг, тэрээр башир аргатай мөн олон зусар үгтэй хүн байсан учир, олон хүмүүний зүрх сэтгэлийг ёс бусыг хийхэд; тийм ээ, мөн Бурханы сүмийг устгахыг, мөн Бурханы тэдэнд соёрхсон, өөрөөр хэлбэл “зөв шударгыг үйлдэгсдийн төлөө бүх нутгийн гадаргуу дээр адислал болгон Бурханы

илгээсэн тэрхүү ⁶эрх чөлөөний үндэс суурийг устгахыг эрэлхийлэхэд тэр удирдсаныг бид харлаа.

11 Мөн эдүгээ улиран тохиох дор нифайчуудын их цэргийн “ерөнхий захирагч, Моронай эдгээр тэрслэлүүдийг сонсоод, тэрээр Амаликаяд ууртай байв.

12 Мөнхүү улиран тохиох дор тэр нөмрөгөө урж; мөн үүнийхээ нэг хэсгийг нь авч, мөн үүн дээрээ — Бурханы минь, бидний шашин шүтлэгийн, мөн эрх чөлөөний, мөн бидний энх амгалангийн, эхнэр, мөн хүүхдийн минь тухай “санамж болгоё — хэмээн бичиж, мөн тэрээр үүнийг савааны үзүүрт тогтоов.

13 Мөн тэрээр дуулга, мөн цээжний хуяг, мөн бамбай халхавчнуудаа зүүгээд, мөн хуягаа хэвлийн тус газраа агсав; мөн үзүүрт нь түүний урагдсан нөмрөг байлаа, (мөн тэр үүнийг эрх чөлөөний туг гэж нэрлэжээ) тэр савааг аваад мөн тэрээр газарт бөхийн сууж, мөн ах дүүсийнхээ дээр эрх чөлөөний адислалууд байгаасай хэмээн Бурхандаа хүчтэйгээр залбирав, Христийнх хэмээгдэх хэсэг уг нутгийг эзэмшихээр үлдсэн цагт буюу —

14 Учир нь Бурханы сүмд харьяалагдсан, Христийн жинхэнэ итгэгчид бүгдээрээ сүмд харьяалагдаагүй тэднээр тийн нэрлэгдсэн байв.

15 Мөн сүмд харьяалагдсан тэд итгэлтэй байв; тийм ээ, Христэд жинхэнэ итгэгчид болох тэд, ирэх тэрхүү Христэд итгэх итгэлийнхээ учир бүгд, “Христийн нэрийг эсвээс нэрлэгдсэнээрээ ⁶Христийнх гэгдэхийг өөрсдийн дээр дуртайяа хүлээн авчээ.

16 Мөн тиймийн тул, энэ үед, Христийнхний хөдөлгөөн мөн уг нутгийн эрх чөлөө тааллыг олж болохын төлөө Моронай залбирав.

17 Мөнхүү улиран тохиох дор тэрээр өөрийн сэтгэлийг Бурханд юүлсний дараа, тэр “Эзгүйрлийн нутгаас өмнөд дэх бүх нутгийг, тийм ээ, мөн дүгнэж хэлэхэд, бүх нутгийг умард ба өмнөдөд аль алинд нь байх — сонгомол нутаг, мөн эрх чөлөөний нутаг хэмээн нэрлэв.

18 Мөн тэрээр хэлэв: Бид Христийн нэрийг өөрсдийн дээр авсан учир гадуурхагдсан биднийг доор дэвслэгдэхийг мөн устгагдахыг, бид үүнийг өөрсдийнхөө дээр зөрчлүүдээрээ авчрах хүртэл Бурхан тэвчихгүй нь лавтай.

19 Мөн Моронай эдгээр үгсийг хэлээд, тэр хүмүүсийн дунд явж, нөгөөх урагдсан хэсэг дээрх өөрийнх нь бичсэнийг бүгд харж болохын тулд, “өмсгөлийнхөө урагдсан хэсгээр агаарт даллан, мөн чанга дуугаар хашгирч, хэлсэн нь:

20 Болгоогтун, уг нутагт энэ

10б 2 Ниф. 1:7;
Мозая 29:32.
11а Алма 43:16–17.

12а Нех. 4:14; Алма 44:5.
15а Мозая 5:7–9.
б Үйлс 11:26;

1 Петр 4:16.
17а Алма 22:30–31.
19а су Туг.

тугийг хадгалахаар сонгосон хэн боловч, тэд Их Эзэний хүчинд нааш ирж, мөн Их Эзэн Бурхан тэднийг адисалж болохын тулд эрхээ, мөн шашин шүтлэгээ хадгалах болно гэсэн гэрээнд нэгдэгтүн.

21 Мөнхүү улиран тохиох дор Моронай эдгээр үгийг тунхаглахад, болгоогтун, уг хүмүүс хуягаа хэвлийн тус газраа бүслээд, тэд Их Эзэн Бурханаа орхихгүй эсвээс өөр үгээр хэлбэл, хэрэв тэд Бурханы зарлигуудыг зөрчих, эсвээс зөрчилд унаж, мөн Христийн нэрийг өөрсдийн дээр авахаас ичих аваас, тэд хувцсаа урж тасдсан шиг Их Эзэн тэднийг урвал зохино гэсний тэмдэг буюу гэрээ болгон өмсгөлүүдээ урж гүүлдэн ирцгээв.

22 Эдүгээ энэ нь тэдний хийсэн гэрээ байв. Мөн тэд өмсгөлүүдээ Моронайн хөлд хаяж, хэлсэн нь: Хэрэв бид зөрчилд унах аваас, уг нутгийн умард хэсэгт байсан ах дүүсийнхээ адил устгагдах болно хэмээн бид Бурхантайгаа гэрээлэв; тийм ээ, бүр бид өмсгөлүүдээ хөл доор дэвслэгдсэн байхаар таны хөлд хаясны адилаар, хэрэв бид зөрчилд унах аваас тэр биднийг дайснуудын минь хөлд хаяж болно.

23 Моронай тэдэнд хэлэв: Болгоогтун, бид Иаковын үр удмын үлдэгдэл билээ; тийм

ээ, түүний “дээл ах нараар нь олон хэсэг тасчуулсан” Иосефын “үр удмын үлдэгдэл билээ бид; тийм ээ, мөн эдүгээ болгоогтун, Бурханы зарлигуудыг дагахаа санацгаая, эс бөгөөс бидний өмсгөлүүд ах дүүсээр маань тасчигдан, мөн бид гянданд хаягдан, эсвээс худалдагдаж, эсвээс алагдах болно.

24 Тийм ээ, Иосефын “үлдэгдлийн хувьд эрх чөлөөгөө хадгалан хамгаалцгаая, тийм ээ, Иаков үхлийнхээ өмнө хэлсэн үгийг санацгаая, учир нь болгоогтун, тэрээр Иосефын дээлний үлдэгдлийн нэг хэсэг нь хадгалагдаж мөн үжирч муудаагүйг харсан бөлгөө. Мөн тэр хэлсэн нь — Миний хүүгийн хувцасны энэ үлдэгдэл хадгалагдан үлдсэний адил, тэрчлэн хүүгийн минь үр удмын нэгэн “үлдэгдэл Бурханы мутраар хадгалагдан үлдсэн байжээ, мөн түүнд өөрт нь хүлээн авагдах болно, Иосефын үр удмын бусад үлдэгдэл яг түүний өмсгөлийн үлдэгдэл мэт мөхөж байхад буюу.

25 Эдүгээ болгоогтун, энэ нь бодгальд минь харууслыг өгдөг; гэсэн хэдий ч, бодгаль минь хүүдээ баясдаг, Бурханд авагдах түүний үр удмын нэг хэсгийн учир бөлгөө.

26 Эдүгээ болгоогтун, энэ бол Иаковын үг яриа байжээ.

27 Мөн эдүгээ түүний өмс-

21a 1 Ниф. 8:25–28;
Морм. 8:38.

23a Эхл. 37:3, 31–36.

б су Иосеф, Иаковын

хүү.

в Эхл. 49:22–26;

1 Ниф. 5:14–15.

24a Амос 5:15;

3 Ниф. 5:21–24; 10:17.

б 2 Ниф. 3:5–24;

Ифер 13:6–7.

гөл лугаа адил мөхөх Иосефын үр удмын үлдэгдэл нь, биднээс тэрсэлсэн тэд байхыг хэн мэдэх билээ? Тийм ээ, мөн хэрэв бид Христэд итгэх итгэлдээ гуйвшгүйгээр зогсохгүй аваас бүр энэ нь бид өөрсдөө байх болно.

28 Мөн эдүгээ улиран тохиох дор Моронай эдгээр үгсийг хэлээд, тэрээр урагш алхаж, мөн түүнчлэн нутгийн тэрсэлдээн байсан тэр бүх хэсгүүдэд үг илгээж, мөн эрх чөлөөгөө хадгалах хүсэлтэй бүх хүмүүсийг, амаликаячууд гэж нэрлэн Амаликая мөн тэрсэлсэн тэдний эсрэг зогсохоор нэгтгэн цуглуулав.

29 Мөнхүү улиран тохиох дор Амаликая Моронайн хүмүүсийг амаликаячуудаас илүү олон тоотойг хараад — мөн өөрийнх нь хүмүүс эхлүүлсэн хөдөлгөөнийхөө шударга эсэх талаар эргэлзэж буйг тэрээр түүнчлэн үзэв — тиймийн тул, зорьсондоо хүрэхгүй байх хэмээн айсны учир, тэрээр өөрийн хүмүүсээс өөртэй нь хамт явах тэднийг авч мөн Нифайн нутаг тийш одов.

30 Эдүгээ Моронай леменчүүд илүү хүчийг авах нь зохистой бус хэмээн боджээ; тиймийн тул тэрээр Амаликаягийн хүмүүсийг зогсоох, эсвээс тэднийг гүйцэж мөн буцаан авчрах, мөн Амаликаяг үхэлд хүргэхээр бодсон ажээ; тийм ээ, учир нь өөрсдийнх нь эсрэг уурлуула-

хаар леменчүүдийг Амаликая өдөөн хатгаж, мөн өөрсдийнх нь эсрэг тулалдахаар ирэхэд тэднийг хүргэнэ гэдгийг тэр мэдэж байв; мөн Амаликая зорилгодоо хүрч болохын тулд үүнийг хийнэ гэдгийг тэр мэдэж байв.

31 Тиймийн тул Моронай нэгдэн цугларсан, мөн өөрсдийгөө ээвсэглэж энхийг сахих гэрээнд орсон их цэргээ авбал зохино хэмээн бодсон ажээ — мөн улиран тохиох дор тэрээр их цэргээ авч мөн майхнуудтайгаа аглаг буйдахь Амаликаягийн замыг хааж зогсоохоор аглаг буйд тийш жагсан одов.

32 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүслийнхээ дагуу хийж, мөн аглаг буйдад жагсан алхсаар, мөн Амаликаягийн их цэргийг гүйцэв.

33 Мөн улиран тохиох дор Амаликая өөрийн хүмүүсээс цөөн хэдтэй нь зугтаж мөн үлдсэн нь Моронайн гарт орж мөн Зарахемла нутагт буцаан хүргэгдэв.

34 Эдүгээ, Моронай ерөнхий шүүгчдээр мөн хүмүүсийн дуу хоолойгоор “томилогдсон хүн байсан учир, тиймийн тул тааллынхаа дагуу нифайчуудын их цэргийн дээр эрх мэдлээ зарлаж мөн үзүүлэх хүч түүнд байв.

35 Мөнхүү улиран тохиох дор амаликаячуудаас тэд чөлөөт засаглалыг дэмжиж болохын тулд, эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжих гэрээнд

орохгүй байсан хэнийг боловч, үхэлд хүргэгдэх болгов; мөн эрх чөлөөний гэрээнээс татгалзсан нь цөөн хэдхэн байв.

36 Мөнхүү улиран тохиох дор, түүнчлэн тэр нифайчуудаар эзэмшигдэж байсан тэр бүх нутаг даяар цамхаг болгон дээр эрх чөлөөний туг өргөгдөх болгов; мөн ийн Моронай эрх чөлөөний далбааг нифайчуудын дунд босгов.

37 Мөн уг нутагт тэд дахин энх амгалан байж эхлэв; мөн тийн тэд бараг шүүгчдийн засаглалын арван есдүгээр оны эцсийг хүртэл уг нутагт энх амгаланг хадгалав.

38 Мөн Хиламан болон “дээд санваартнууд түүнчлэн сүм дэх журмыг хадгалав; тийм ээ, бүр дөрвөн жилийн турш сүмийн дотор тэдэнд их амгалан мөн баясал байв.

39 Мөнхүү улиран тохиох дор тэдний сүнснүүд Их Эзэн Есүс Христээр гэтэлгэгдсэн хэмээн хатуу “итгэсээр үхсэн нь олон байв; тийн тэд баясаар дэлхийгээс одов.

40 Мөн зарим нь, жилийн зарим улиралд уг нутагт маш ойр ойрхон тохиолддог халуунаас үхэв—гэвч төдий олон нь халуунаас болсонгүй, учир нь цаг агаарын учир хүмүүний тусах өвчний эх үүсвэрийг зайлуулахаар Бурханы бэлтгэсэн олон “ургамал мөн үндсүүдийн онц сайн чанартайгаас буюу —

41 Харин насны өндрөөс үхсэн нь олон байв; мөн Христэд итгэсээр наснаас хальсан тэд түүнтэй хамт “аз жаргалтай байгаа, бид тийн бодох ёстой.

БҮЛЭГ 47

Амаликая леменчүүдийн хаан болохын тулд итгэл эвдэх урвалт, аллага мөн нууц явуулга хэрэглэв — Нифай үндэсний тэрслэгчид леменчүүдээс илүү ёс бус мөн хэрцгий догшин байв. Ойролцоогоор мээ 72 он.

Эдүгээ бид Амаликая болон түүнтэй хамт аглаг буйд тийш “зугтсан тэдний цэдэгт эргэн орцгооё; учир нь, болгоогтун, тэрээр өөртэйгөө явсан тэднийг авч, мөн Нифайн нутагт леменчүүдийн дунд одсон байв, мөн Нифайн хүмүүсийн эсрэг уурлуулахаар леменчүүдийг өдөөн хатгав, үүний хэрээр леменчүүдийн хаан өөрийн бүх нутаг даяар, өөрийн бүх хүмүүсийн дунд, тэд нифайчуудын эсрэг тулалдахаар явахын тулд дахин нэгдэн цугларцгаа хэмээн зар илгээв.

2 Мөнхүү улиран тохиох дор тэдний дунд зар түгэхэд тэд үлэмж айв; тийм ээ, тэд хааны дургүйцлийг хүргэхээс айв, мөн түүнчлэн тэд амиа алдах болов хэмээн Нифайчуудын эсрэг тулалдахаар явахаасаа айсан ажээ. Мөнхүү

38a Алма 46:6.

39a Моро. 7:3, 41.

40a С ба Г 89:10.

41a Илч. 14:13.

47 1a Алма 46:33.

б 2 Ниф. 5:5–8;

Омнаи 1:12–13.

улиран тохиох дор тэд, эсвээс тэдний ихэнх хэсэг нь хааны зарлигуудыг дагах хүсэлгүй байв.

3 Мөн эдүгээ улиран тохиох дор тэдний дуулгаваргүй байдлын учир хаан хилэгнэв; тиймийн тул тэрээр өөрийн зарлигуудад дуулгавартай байсан их цэргийнхээ тэр хэсгийн удирдлагыг Амаликаяд өгч, мөн явж мөн тэднийг эвсэглэхийг албадахыг түүнд зарлиглав.

4 Эдүгээ болгоогтун, энэ нь Амаликаагийн хүсэл байв; учир нь тэр хилэнцийг хийхдээ маш зальтай хүн байсан учир, тиймийн тул леменчүүдийн хааныг сэнтийнээс нь буулгах төлөвлөгөөг тэр зүрх сэтгэлдээ агуулж байв.

5 Мөн эдүгээ тэрээр хааны талд байсан леменчүүдийн тэдгээр хэсгүүдийн удирдлагыг авав; мөн тэр дуулгаваргүй байсан тэдний тааллыг олохыг эрэлхийлж байв; тиймийн тул бүх леменчүүд тийшээ зугтсан учир, “Онида гэж нэрлэгдсэн газар тэрээр очив; тэд их цэрэг ирж явааг олж мэдсэний учир, мөн өөрсдийг нь устгахаар тэд ирж буй хэмээн бодоод, тиймийн тул тэд Онидагийн зүг, эвсэглэх газрынхаа зүг зугтсан ажээ.

6 Мөн тэд өөрсдийн дээр хаан мөн удирдагч байх хүнийг томилсон байв, тэд нифайчуудын эсрэг явахад хамрагдахгүй хэмээн хатуу шийдэмгийгээр сэтгэл оюу-

наа хандуулсан байсны учир болой.

7 Мөнхүү улиран тохиох дор тэд тулалдахаар бэлтгэж, Антипас гэж нэрлэгдсэн уулын орой дээр өөрсдөө цугларцгаасан байв.

8 Эдүгээ хааны зарлигуудын дагуу тэдэнтэй тулалдах нь Амаликаагийн санаа биш байв; гэвч болгоогтун, тэрээр өөрийгөө тэдний толгойлогч болгож мөн хааныг сэнтийнээс нь буулгаж бас хаант улсын эзэмшлийг авахын тулд леменчүүдийн их цэргийн тааллыг олох нь түүний санаа байжээ.

9 Мөн болгоогтун, улиран тохиох дор тэрээр өөрийн их цэргийг Антипас уулын дэргэдэх хөндийд майхнуудаа босгох болгов.

10 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр нууц элчийг шөнөөр Антипас ууланд илгээж, уулан дээр байсан тэдний удирдагч, Лихонти гэгчээс тэр түүнтэй ярихыг хүссэн тул доош бууж уулын бэлд ирэхийг хүсэв.

11 Мөнхүү улиран тохиох дор Лихонти мэдээг хүлээж аваад тэрээр уулын бэл уруу бууж зүрхэлсэнгүй. Мөнхүү улиран тохиох дор Амаликаа хоёр дахь удаагаа хүн илгээж, түүнийг доош бууж ирэхийг хүсэв. Мөнхүү улиран тохиох дор Лихонти тэгсэнгүй; мөн тэрээр дахин гурав дахь удаагаа илгээв.

12 Мөнхүү улиран тохиох

дор Лихонтиг уулнаас буулган ирж чадахгүйгээ Амаликая мэдээд, тэрээр уул оод гарч, Лихонтийн бараг л буудалд нь очив; мөн түүнийг бууж ирэхийг хүсэн тэрээр мэдээгээ Лихонтид дахин дөрөв дэх удаагаа илгээж, харуулуудаа өөртэйгөө хамт авч ирэхийг түүнээс хүсэв.

13 Мөнхүү улиран тохиох дор Лихонти харуулуудтайгаа хамт бууж Амаликаяд ирэхэд, Амаликая түүнээс шөнийн цагаар их цэргээ аван бууж ирээд, мөн буудалд байгаа хааны түүнд захиргааг нь өгсөн тэднийг бүслэн авахыг хүсч, мөн хэрэв тэр түүнийг (Амаликаят) бүх цэргийн дээр хоёр дахь удирдагч болговол тэр тэднийг Лихонтийн гарт оруулна хэмээв.

14 Мөнхүү улиран тохиох дор Лихонти эрчүүдтэйгээ бууж ирээд мөн Амаликаягийн эрчүүдийг бүслэв, иймээс үүрээр сэрэхээсээ өмнө тэд Лихонтийн их цэрэгт бүслэгдсэн байв.

15 Мөнхүү улиран тохиох дор бүслэгдсэнээ тэд хараад, тэд устгагдахгүйн тулд ах дүүстэйгээ нэгдэхийг зөвшөөрөхийг тэд Амаликаагаас гуйв. Эдүгээ энэ нь Амаликаягийн хүссэн чухам тэр зүйл байв.

16 Мөнхүү улиран тохиох дор тэр хааны зарлигуудын “эсрэгээр өөрийн хүмүүсийг мэдэлд нь өгөв. Эдүгээ хааныг сэнтийнээс нь буулгах

аргаа тэрээр хэрэгжүүлж болохын тулд, Амаликаягийн хүссэн тэр зүйл нь энэ байв.

17 Эдүгээ хэрэв тэдний ерөнхий удирдагч нь алагдвал, хоёр дахь удирдагчийг өөрсдийн ерөнхий удирдагчаар томилох нь леменчүүдийн дундах заншил байв.

18 Мөнхүү улиран тохиох дор Амаликая өөрийн зарц нарын нэгээр Лихонтид бага багаар хор өгүүлж, ингээд тэр үхэв.

19 Эдүгээ, Лихонтиг үхсэний дараа, леменчүүд Амаликаят өөрсдийн удирдагч бөгөөд ерөнхий захирагчаа байхаар томилов.

20 Мөнхүү улиран тохиох дор Амаликая их цэрэгтэйгээ (учир нь тэр хүслээ гүйцээсэн бөлгөө) Нифайн нутаг тийш, гол хот асан тэр Нифай хотын зүг хөдлөв.

21 Мөн хаан түүнтэй уулзахаар харуулуудтайгаа гарч ирэв, учир нь тэр Амаликаят өөрийнх нь зарлигуудыг биелүүлсэн, мөн Амаликая Нифайчуудын эсрэг тулалдахаар явах ийм агуу олноор их цэргийг нэгтгэн цуглуулсан хэмээн боджээ.

22 Гэвч болгоогтун, хаан түүнтэй уулзахаар гарч ирэхэд Амаликая зарц нараа хаантай уулзуулахаар явуулав. Мөн тэд очиж мөн хааны өмнө түүний агуу ихийн учир түүнийг бишрэн хүндэтгэх мэт бөхийв.

23 Мөнхүү улиран тохиох дор тэдний нифайчуудаас авсан

тэдний заншил болох леменчүүдийн заншлаар, амар амгалангийн тэмдэг болгож тэднийг босгохоор хаан гараа урагш сунгав.

24 Мөнхүү улиран тохиох дор тэрээр эхний хүнийг газраас босгомгоц, болгоогтун тэрээр хааны зүрхэнд хутгалав; мөн тэрээр хөсөр ойчив.

25 Эдүгээ хааны зарц нар зугтав; мөн Амаликаягийн зарц нар дуугаа өргөн хашгирч, хэлсэн нь:

26 Болгоогтун, хааны зарц нар түүнийг зүрхэнд хутгалав, мөн тэр унаж мөн тэд зугтав; болгоогтун, ирж мөн хар.

27 Мөнхүү улиран тохиох дор Амаликая өөрийн цэргийг урагш алхалж мөн хаанд юу тохиолдсоныг хар хэмээн зарлиглав; мөн тэд уг газар ирэхэд, мөн хаан цусандаа хутгалдан хэвтэж буйг олоход, Амаликая хилэгнэж буй дүр үзүүлж, мөн хэлэв: Хаанд хайртай байсан хэн боловч, явж мөн түүний зарц нарыг тэд алагдахын тулд мөрдөн хөөг.

28 Мөнхүү улиран тохиох дор хааныг хайрладаг байсан тэд эдгээр үгийг сонсоод урагш одож мөн хааны зарц нарын араас мөшгөн хөөв.

29 Эдүгээ хааны зарц нар их цэрэг тэдний араас мөрдөн айсууг хараад, тэд дахин айж, мөн аглаг буйд тийш зугтав, мөн Зарахемла нутагт ирж мөн Аммоны “хүмүүстэй нэгдэв.

30 Мөн тэдний араас мөрдсөн их цэрэг, тэдний араас хоосон мөрдөөд буцаж ирэв; мөн тийн Амаликая, заль мэхээрээ хүмүүсийн зүрх сэтгэлийг эзэмдэв.

31 Мөнхүү улиран тохиох дор маргааш нь тэр Нифайн хотод их цэргийнхээ хамт орж, мөн хотын эзэмшлийг авав.

32 Мөн эдүгээ улиран тохиох дор хатан, хаан алагдсаныг сонсоод—учир нь хаан зарц нартаа алагдаж, Амаликая тэднийг их цэрэгтэйгээ мөрдсөн боловч энэ нь хоосон байж мөн тэд оргон зайлж амжсаныг түүнд мэдээлэн тэрээр хатанд элч илгээсэн ажээ—

33 Тиймийн тул, хатан энэ мэдээг хүлээн аваад Амаликаяд илгээж, хотын хүмүүсийг өршөөн хэлтрүүлэхийг түүнээс хүсэв; мөн түүнчлэн тэр эмэгтэй өөр дээрээ ирэхийг хүсэв; мөн түүнчлэн тэр эмэгтэй хааны үхлийн талаар гэрчлэх гэрчүүдийг өөртэйгөө хамт авчрахыг түүнээс хүсэв.

34 Мөнхүү улиран тохиох дор Амаликая хааныг алсан тэрхүү зарцыг, мөн түүнтэй хамт байсан тэд бүгдийг авч, мөн хатанд, түүний сууж байсан газар очив; мөн тэд бүгд хаан зарц нартаа алагдсаныг түүнд гэрчлэв; мөн түүнчлэн тэд хэлэв: Тэд зугтсан; энэ нь тэдний эсрэг гэрчлэхгүй байна гэж үү? Мөн тийн хааны үхлийн талаарх хатны эргэлзээг тэд арилгав.

35 Мөнхүү улиран тохиох дор Амаликая хатны тааллыг эрэлхийлж, мөн түүнийг өөртөө эхнэр болгон авав; мөн тийн заль мэхээрээ, мөн башир аргат зарц нарынхаа туслалцаатайгаар, тэр хаант улсыг эзлэв; тийм ээ, тэр бүх нутаг даяар, леменчүүд мөн лемүелчүүд мөн ишмэйлчүүдээс мөн Нифайн засаглалаас одоог хүртэлх нифайчуудын бүх тэрслэгчдээс “бүрдсэн тэр бүх леменчүүдийн ард түмний дунд хаан хэмээн хүлээн зөвшөөрөгдөв.

36 Эдүгээ эдгээр “тэрслэгчид нь, нифайчуудын нэгэн адил заавар мөн нэгэн адил мэдээллийг авсан байв, тийм ээ, Их Эзэний тухай нэг адил мэдлэгт сургагдсан байлаа, гэсэн хэдий ч тэрслэснийхээ дараа тэд тун удалгүй леменчүүдээс ч илүү хатуу мөн “гэмшдэггүй, мөн илүү зэрлэг, ёс бус мөн догшин хэрцгий болцгоосон байсныг дурдах нь хачирхалтай юм — леменчүүдийн зан заншилд уусаж; залхуу байдалдаа мөн бүх төрлийн тачаангуйлалд автагдсан байв; тийм ээ, Их Эзэн Бурханаа бүрмөсөн мартсан байв.

БҮЛЭГ 48

Амаликая леменчүүдийг нифайчуудын эсрэг турхирав— Моронай өөрийн хүмүүсийг Христийнхний хөдөлгөөнийг

дэмжихэд бэлтгэв—Тэрээр эрх чөлөө хийгээд чөлөөт байдалд баяссан мөн Бурханы хувьд хүчит хүмүүн байв. Ойролцоогоор мээ 72 он.

Мөнхүү эдүгээ улиран тохиох дор, Амаликая хаант улсыг авмагцаа леменчүүдийн зүрх сэтгэлийг Нифайн хүмүүсийн эсрэг дэвэргэж эхлэв; тийм ээ, цамхгууд дээрээсээ нифайчуудын эсрэг ярих хүмүүсийг тэр леменчүүдэд томилсон болой.

2 Мөн тийн тэр тэдний зүрх сэтгэлийг нифайчуудын эсрэг дэвэргэж, үүний хэрээр шүүгчдийн засаглалын арван ес дэх оны төгсгөлд, тэрээр өдийг хүртэл өөрийн төлөвлөгөөнүүдийг гүйцэлдүүлсэн учир, тийм ээ, леменчүүдийн дээр хаан болгогдсон учир, тэр бүх нутгийн дээр, тийм ээ, мөн уг нутагт байсан бүх хүмүүсийн дээр, леменчүүдийн нэг адил нифайчуудын дээр түүнчлэн засаглахыг эрэлхийлсэн бөлгөө.

3 Тиймийн тул тэр санаагаа гүйцээсэн аж, учир нь тэр леменчүүдийн зүрхийг хатууруулж мөн оюуныг нь харалган болгож, мөн уурлуулахаар тэднийг өдөөн хатгаж, үүний хэрээр тэр нифайчуудын эсрэг тулалдахаар явах олон тооны дайчдыг нэгтгэн цуглуулсан байв

4 Учир нь тэр, өөрийн хүмүүсийн тооны ихийн учир, нифайчуудыг давамгайлж

мөн тэднийг дарангуйлалд авчрахаар шийдсэн байлаа.

5 Мөн тийн тэрээр зорамчуудаас “ерөнхий ахмадуудыг томилов, учир нь нифайчуудын хүч чадал, мөн тэдний хоргодох газрууд, мөн хотуудынх нь хамгийн хүч султай хэсгүүдийг сайн мэддэг байсан нь тэд байв; тиймийн тул тэрээр тэднийг их цэргийнхээ дээр ерөнхий ахмадууд байхаар томилов.

6 Мөнхүү улиран тохиох дор тэд өөрсдийн буудлыг авч, мөн Зарахемла нутгийн зүг аглаг буйдад нүүдэллэв.

7 Эдүгээ улиран тохиох дор Амаликая ийн заль мэх мөн луйвраар хүчийг олж байхад, нөгөө талд, Моронай хүмүүсийн оюуныг Их Эзэн Бурхандаа итгэлтэй байхад “бэлтгэж байв.

8 Тийм ээ, тэр нифайчуудын их цэргийг хүчирхэгжүүлж, мөн жижиг бэхлэлтүүдийг, эсвээс хоргодох газруудыг босгож байв; их цэргээ халхлахаар газрын эргийг өндөрлөж, мөн түүнчлэн тэднийг тойруулан, хотуудынхаа мөн нутгийнхаа хилийг хүрээлүүлэн; тийм ээ, нутгийг бүхэлд нь хүрээлүүлэн чулуун хэрэм босгов.

9 Мөн өөрсдийн хамгийн хүч султай бэхлэлтэнд илүү олон тооны эрчүүдийг тэрээр байрлуулжээ; мөн тийн тэрээр нифайчуудаар

эзэмшигдэж асан тэр нутгаа бэхэлж мөн хүчирхэгжүүлжээ.

10 Мөн тийн тэрээр тэд Их Эзэн Бурханыхаа төлөө амьдарч болохын тулд, мөн тэд дайснаудаар нь Христийнхний хөдөлгөөн гэж нэрлэгдсэн түүнийгээ хадгалж болохын тулд чөлөөт байдлаа, газар нутгаа, эхнэр, мөн хүүхдүүдээ, мөн өөрсдийн амар амгаланг “хамгаалахаар бэлтгэж байв.

11 Мөн Моронай хүчтэй мөн чадалтай хүн байв; тэр төгс “ойлголттой хүн байв; тийм ээ, цус урсалтанд баясдаггүй нэгэн байв; ах дүүс нь дарангуйлал мөн боолчлолоос чөлөөтэй байхад мөн төрөлх орныхоо чөлөөт байдал хийгээд эрх чөлөөнд бодгаль нь баясдаг хүн байв;

12 Тийм ээ, Бурхандаа талархах талархлаар зүрх сэтгэл нь тэлдэг хүн байв, хүмүүсийнх нь дээр түүний цутгасан олон боломжууд хийгээд адислалуудын учир болой; өөрийн хүмүүсийн “аз жаргал болоод аюулгүй байдлын төлөө үлэмж хөдөлмөрлөдөг хүн байв.

13 Тийм ээ, мөн тэрээр Христийн итгэлд гуйвшгүй хүн байв; мөн тэрээр ард түмнээ, эрхүүдээ, мөн төрөлх орноо, мөн шашин шүтлэгээ, бүр өөрийн цусыг шавхах хүртлээ өмгөөлөхөөр “тангараг тавьсан байв.

14 Эдүгээ нифайчууд дайснуудынхаа эсрэг, бүр хэрэв зайлшгүй шаардагдах аваас цус урсгах хүртлээ өөрсдийгөө хамгаалах ёстой хэмээн сургагдсан байв; тийм ээ, мөн түүнчлэн тэд “хэзээ ч хэрэг төвөг өдөөхгүй, тийм ээ, мөн дайснуудынхаа эсрэг бус аваас, амиа хамгаалахаас өөрөөр хэзээ ч илд далайхгүй байх ёстой хэмээн сургагдсан байлаа.

15 Мөн тэдний итгэл ийм байв; үүнчлэн үйлдсэнээр Бурхан тэднийг уг нутагт дэгжүүлнэ эсвээс өөрөөр хэлбэл, хэрэв тэд Бурханы зарлигуудыг дагахдаа итгэлтэй байвал, тэрээр уг нутагт тэднийг дэгжүүлэх болно; тийм ээ, тэдэнд аюултайнх нь дагуу, тэдэнд зугтахыг, эсвээс дайнд бэлтгэхийг сэргэмжлүүлэх бөлгөө;

16 Мөн түүнчлэн, дайснуудынхаа эсрэг өөрсдийгөө хамгаалахаар тэдний хааш одох ёстойг Бурхан тэдэнд мэдүүлнэ, мөн ингэснээр, Их Эзэн тэднийг чөлөөлөх буюу; мөн энэ нь Моронайн итгэл байв, мөн зүрх сэтгэл нь үүнд баясдаг байв; “цус урсгахад бус харин сайныг үйлдэхэд, өөрийн хүмүүсийг хадгалан хамгаалахад, тийм ээ, Бурханы зарлигуудыг дагахад, тийм ээ, мөн алдсыг эсэргүүцэхэд болой.

17 Тийм ээ, үнэнээр, үнэнээр

би та нарт хэлнэ, хэрэв бүх хүмүүн Моронайн адил байсан мөн байдаг, мөн байх аваас, болгоогтун, тамын чухамхүү хүчин чадал үүрд сэгсрэгдэн сулруулагдах сан; тийм ээ, хүмүүний үрсийн зүрх сэтгэлийг давах хүч “чөтгөрт хэзээ ч байхгүй байх сан.

18 Болгоогтун, Мозаягийн хүү, Аммоны адил хүн, тийм ээ, бүр Мозаягийн бусад хөвгүүдийн адил, тийм ээ, мөн түүнчлэн Алма болон түүний хөвгүүдийн адил байв, учир нь тэд бүгд Бурханы хүмүүс байв.

19 Эдүгээ болгоогтун, Хиламан мөн түүний ах дүүс хүмүүст Моронайгаас дутуугүй үйлчилдэг байв; учир нь тэд Бурханы үгийг номлож, мөн тэд үгсийг нь сонсох хэнийг боловч бүх хүмүүсийг наманчлалд хүргэн баптисм хүртээж байлаа.

20 Мөн тийн тэд урагшлан явж, мөн тэдний үгсийн учир хүмүүс өөрсдийгөө “даруусгаж, үүний хэрээр тэд Их Эзэний өндөр “ээл хишгийг хүртэж мөн тийн өөр хоорондоо; тийм ээ, бүр дөрвөн жилийн турш дайнууд мөн зөрчлүүдээс чөлөөтэй байв.

21 Гэвч миний хэлсэнчлэн, арван есдүгээр оны төгсгөлд, тийм ээ, тэдний дунд энх амгалан байсан хэдий ч,

14a Алма 43:46–47;
3 Ниф. 3:20–21;
Морм. 3:10–11;
С ба Г 98:16.

16a Алма 55:19.
17a 1 Ниф. 22:26;
3 Ниф. 6:15.
20a су Даруу, Даруу

байдал.
б 1 Ниф. 17:35.

тэд өөрсдийн ах дүүс, леменчүүдтэй тэмцэлдэхэд дургүй ч гэсэн албадуулагдсан болой.

22 Тийм ээ, мөн эцэст нь, тэд маш их дургүй байсан хэдий ч, леменчүүдтэй хийсэн тэдний дайнууд олон жилийн турш огт зогссонгүй.

23 Эдүгээ, тэд леменчүүдийн эсрэг зэвсэглэхэд “харамсаж байв, учир юун гэвэл цус урсахад тэд баясаг байсангүй; тийм ээ, мөн энэ нь бүгд бус—тэд ах дүүсээсээ тийм олныг нь Бурхантай уулзах бэлтгэлгүйгээр, энэ дэлхийгээс мөнхийн оронд илгээх хэрэгсэл болж байгаадаа харамсаж байлаа.

24 Гэсэн хэдий ч, тэд амиа тавьж өгөхийг хүлцэж чадсангүй, нэгэн цагт ах дүүс нь байсан, тийм ээ, мөн өөрсдийн сүмээс “тэрсэлсэн, мөн тэднийг орхиж мөн леменчүүдтэй нэгдсэнээр тэднийг устгахаар одсон тэдний харгис хэрцгийлэлд ^бэхнэр хүүхдүүд нь хядагдах байсны учир буюу.

25 Тийм ээ, Бурханы зарлигуудыг дагадаг хэн нэгэн байх цагт, ах дүүс нь нифайчуудын цусыг шавхахдаа баясахыг тэд тэвчиж чадсангүй, учир нь, хэрэв тэд түүний зарлигуудыг дагах аваас тэд уг нутагт дэгжих болно хэмээх Их Эзэний амлалт байв.

БҮЛЭГ 49

Халдан довтлох леменчүүд Аммонайха болон Ноагийн бэхлэгдсэн хотуудыг авах боломжгүй байв—Амаликая Бурханыг зүхэж мөн Моронайн цусыг уухаар тангараг тавив—Хиламан болон түүний ах дүүс Сүмийг хүчирхэгжүүлэхээ үргэлжлүүлэв. Ойролцоогоор мээ 72 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор арван есдүгээр оны арван нэгдүгээр сард, уг сарын арав дахь өдөр, леменчүүдийн их цэрэг Аммонайха нутгийн зүг ойртож буй нь харагдав.

2 Мөн болгоогтун, уг хот сэргээн босгогдсон байв, мөн Моронай хотын хилийн дагуу их цэргийг байрлуулсан ажгуу, мөн тэд леменчүүдийн сум мөн чулуунаас өөрсдийгөө халхлах гэж шороогоор тойруулан хаалт болгосон байв; учир нь болгоогтун тэд чулуугаар мөн нум сумаар байлддаг байжээ.

3 Болгоогтун би “Аммонайха хот сэргээн босгогдсоныг хэлэв. Би та нарт хэлнэ, тийм ээ, энэ нь хэсэгчлэн сэргээн босгогдсон байлаа; мөн хүмүүсийнх нь алдсын учир леменчүүд үүнийг нэгэнтээ устгасан учир, энэ нь тэдний хувьд дахин амархан олз болно хэмээн тэд бодсон ажгуу.

4 Гэвч болгоогтун тэдний гутрал хичнээн агуу байв; учир нь болгоогтун, лемен-

чүүд өөрсдийн чулууг мөн сумнуудаа үр дүнтэйгээр тэдний дээр буулгаж, бас орц газраар бус аваас тэдэн дээр ирж чадахааргүй тийм өндөрт нифайчууд өөрсдийгөө тойруулан шороогоор далан босгожээ.

5 Эдүгээ энэ үед хориглох газруудаа бэлтгэхэд гаргасан нифайчуудын мэргэн ухааны учир леменчүүдийн ерөнхий ахмадууд үлэмж гайхан цочирдсон аж.

6 Эдүгээ леменчүүдийн удирдагчид өөрсдийнх нь тоо агуу олны учир ийн бодсон байв, тийм ээ, тэд урьд нь тэгж байсныхаа адил тэднийг даван ирэх боломжтой байх болно хэмээн бодсон ажгуу; тийм ээ, мөн түүнчлэн тэд өөрсдийгөө бамбай мөн цээжний хуягуудтайгаар бэлтгэсэн байв; мөн түүнчлэн тэд өөрсдийгөө арьсан өмсгөлүүдтэйгээр, тийм ээ, нүцгэнийг нь халхалсан маш зузаан өмсгөлүүд тэйгээр бэлтгэсэн байв.

7 Мөн тийн бэлтгэснээс өөрсдийн тааллын дагуу тэд ах дүүсээ амархан давамгайлж мөн дарангуйллын буулганд харьяалуулж, эсвээс тэднийг алж мөн хядах болно хэмээн боджээ.

8 Гэвч болгоогтун, тэднийг бүрмөсөн гайхан цочирдуулсан нь, тэднийг ирэхэд тэд Лихайн үрсийн дунд хэзээ ч мэдэгдээгүй тийм маягаар “бэлтгэчихсэн байв. Эдүгээ

тэд леменчүүдийг ирэхэд Моронайн заавруудын дагуу тулалдахаар бэлтгэсэн байв.

9 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд, өөрөөр хэлбэл амаликачууд, тэдний дайнд бэлтгэсэн маягийг хараад үлэмж гайхан цочирдов.

10 Эдүгээ хэрэв “Нифайн нутгаас, их цэргээ толгойлон хаан Амаликая ирсэн бол, тэрээр магад леменчүүдийг Аммонайха хот дахь нифайчуудыг довтлохыг албадах байсан буйза; учир нь болгоогтун, тэр өөрийн хүмүүсийн цусыг ч үл хайхрах ажээ.

11 Гэвч болгоогтун, Амаликая өөрөө тулалдахаар ирээгүй байжээ. Мөн болгоогтун, түүний ерөнхий ахмад Аммонайха хот дахь нифайчуудыг довтолж зүрхэлсэнгүй, учир нь Моронай нифайчуудын дундах үйл хэргүүдийг удирдах аргыг өөрчилж, үүний хэрээр леменчүүд тэдний хориглох газруудынх нь учир гутарч мөн тэр тэдний дээр ирж эс чадав.

12 Тиймийн тул тэд аглаг буйд тийш ухарч, мөн буудлаа авч мөн тэдний хувьд нифайчуудын эсрэг дайрах дараагийн хамгийн тохиромжтой газар байна хэмээн бодож Ноа нутгийн зүг жагсан одов.

13 Учир нь бүх нутгийн эргэн тойрон хот болгонд Моронай бэхэлснийг, өөрөөр хэлбэл хамгаалах “бэхлэлтүүд барьсныг тэд мэдсэнгүй;

тиймийн тул, тэд зориг шийдэмгийгээр Ноа нутгийн зүг жагсан явцгаав; тийм ээ, тэдний ерөнхий ахмадууд урагшилж мөн тэд уг хотын хүмүүсийг устгах болно хэмээн тангараг тавив.

14 Гэвч болгоогтун, тэдний гайхшралыг төрүүлсэн нь, Ноагийн хот, урьд нь хүчээр дорой газар байсан тэр нь, эдүгээ Моронайн тусламжтайгаар, хүчирхэг болсон байв, тийм ээ, бүр Аммонайха хотын хүчирхгээс давуу хүчирхэг болсон байв.

15 Мөн эдүгээ, болгоогтун, ингэсэн нь Моронайн мэргэн ухаан байв; учир нь, тэд Аммонайха хотын дэргэд сүрдсэн аж; мөн Ноа хот одоог хүртэл нутгийн хамгийн сул дорой хэсэг байснаас, тиймийн тул тэд тулалдахаар тийш жагсан хөдлөх байх хэмээн тэр боджээ; мөн тийн энэ нь түүний хүслийн дагуу болов.

16 Мөн болгоогтун, Моронай уг хотын эрчүүдийн дээр ерөнхий ахмад болгохоор Лихайг томилсон байв; мөн энэ нь Сидон голын зүүн хөндийд леменчүүдтэй байлдсан “тэрхүү Лихай байв.

17 Мөн эдүгээ болгоогтун улиран тохиох дор, Лихай уг хотыг захирч буйг леменчүүд олж мэдээд тэд дахин гутарцгаав, учир нь тэд Лихайгаас үлэмж айдаг ажээ; гэсэн хэдий ч тэдний ерөнхий ахмадууд уг хотыг довтлохоор

тангараг тавьцгаасан байв; тиймийн тул тэд их цэргээ авчрав.

18 Эдүгээ болгоогтун, леменчүүд тэдний хамгаалалтын бэхлэлтүүдэд орцноос бусад газраар нэвтэрч чадсангүй, учир нь орцноос бусад газар хүрээлэн овоологдсон далангийн өндрөөс мөн ухагдсан шуудууных нь гүнээс буюу.

19 Мөн тийн нифайчууд өөр ямар нэгэн замаар бэхлэлтэнд орох гэж авирахаар завдсан бүгдийг, чулуугаар мөн сумаар харван устгахад бэлтгэсэн байв.

20 Тэд тийн бэлтгэсэн байв, тийм ээ, орц газраар хориглох байранд нь орж ирэхээр завдсан бүгдийг цохож унагахаар тэдний хамгийн хүчтэй эрчүүдийн хэсэг нь илднүүд мөн дүүгүүрүүдтэйгээ; мөн тийн тэд леменчүүдийн эсрэг өөрсдийгөө хамгаалахаар бэлтгэсэн байв.

21 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн ахмадууд их цэргээ орц газрын өмнө авчирч, мөн нифайчуудтай тэдний хориглох газарт нь орохоор тулалдаж эхлэв; гэвч болгоогтун, тэд цагаас цагт буцаан туугдаж, үүний хэрээр тэд асар их аллагаар хөнөөгдөв.

22 Эдүгээ тэд уг орц газраар нифайчуудыг давамгайлах хүчийг олж чадахгүйгээ мэдээд, тэд их цэрэгтээ гарц гаргаж болохын тулд, тэд

тулалдах адил тэгш боломжтой байж болохын тулд шороон даланг нь ухаж эхлэв; гэвч болгоогтун, эдгээр завдлагадаа тэд өөрсдийнх нь дээр буулгасан чулуу мөн сумнуудаар хиар цохигдох нь тэр; мөн шуудуунуудыг нь шороон даланг буулгаж дүүргэхийн оронд, тэдгээр нь тэдний үхэгсэд мөн шархадсан биесээр тодорхой хэмжээгээр дүүргэгдсэн байв.

23 Тийнхүү дайснуудаа давах бүх хүчин нифайчуудад байв; мөн тийн леменчүүд өөрсдийн бүх ерөнхий ахмадуудыг алагдах хүртэл нифайчуудыг устгахаар оролджээ; тийм ээ, мөн леменчүүдийн мянгаас илүү нь алагдав; гэтэл, нөгөөтэйгүүр, нифайчуудаас алагдсан нэг ч бодгаль байсангүй.

24 Орц газраар леменчүүдийн суманд ил байснаас өртөж шархадсан нь тавь орчим байв, гэвч тэд бамбайнуудаараа, мөн цээжний хуяг мөн дуулгаараа халхлагдсан байлаа, үүний хэрээр тэдний шархнууд хөлөнд нь байв, тэдгээрийн олон нь маш ноцтой байжээ.

25 Мөнхүү улиран тохиох дор, леменчүүд өөрсдийн ерөнхий ахмадууд бүгд алагдсаныг хараад тэд аглаг буйд тийш зугтав. Мөнхүү улиран тохиох дор тэд Нифайн нутагт, уг гарал нь нифай

үндэстэн болох тэрхүү өөрсдийн хаан, Амаликаяд их алдагдлынхаа талаар мэдээлэхээр буцаж ирэв.

26 Мөнхүү улиран тохиох дор тэр, өөрийн хүмүүст үлэмж уурлаж байв нифайчуудын тухайд хүслээ гүйцээгээгүй учир; тэр тэднийг дарангуйллын буулганд харьяалуулсангүй.

27 Тийм ээ, тэр үлэмж хилэгнэж, мөн Моронайн цусыг уух болно хэмээн тангараг “тавьж түүнийг мөн түүнчлэн Бурханыг ^бзүхэв; мөн энэ нь Моронай өөрийн хүмүүсийг аюулгүй байдалд бэлтгэхдээ Бурханы зарлигуудыг дагасны учир болой.

28 Мөнхүү улиран тохиох дор, нөгөөтэйгүүр, Нифайн хүмүүс Их Эзэн Бурхандаа, тэднийг дайснуудынх нь гараас чөлөөлсөн түүний зүйрлэшгүй хүчний учир “талархал илэрхийлэв.

29 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арван ес дэх он төгсөв.

30 Тийм ээ, мөн тэдний дунд үргэлжийн амгалан байв, мөн Хиламан, мөн Шиблон, мөн Кориантон, бас Аммон болон түүний ах дүүсээр, тийм ээ, мөн Бурханы “ариун жаягаар томилогдсон, наманчлалд хүргэн баптисм хүртэж, мөн номлохоор хүмүүсийн дунд илгээгдсэн тэд бүгдээр тэдэнд тунхаглагдсан Бурханы

27a Үйлс 23:12.
б су Доромжлох,
Доромжлол.

28a су Талархалтай,
Талархах, Талархал
өргөх.

30a Алма 43:2.

үгэнд хандах тэдний анхаарал мөн хичээнгүй байдлын учир сүмд үлэмж агуу дэгжилт байв.

БҮЛЭГ 50

Моронай нифайчуудын нутгуудыг бэхлэв—Тэд олон шинэ хот босгов—Тэдний ёс бус мөн жигшүүрт хэргүүдийнх нь өдрүүдэд дайнууд болон устгалууд нифайчуудад тохиов—Мориантон болон тэрслэгчид Тианкомд ялагдав—Нифайха нас барж, мөн түүний хүү Пахоран шүүлтийн суудлыг эзлэв. Ойролцоогоор мээ 72–67 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Моронай дайны, эсвээс леменчүүдээс өөрийн хүмүүсийг өмгөөлөхөөр бэлтгэлүүдийг хийхээ зогссонгүй; учир нь, шүүгчдийн засаглалын хорьдугаар оны эхэнд тэрээр өөрийнх нь их цэрэг, Нифайчуудаар эзэмшигдэж асан тэр бүх нутаг даяар, бүх хотуудыг хүрээлүүлэн тэд шороон далангууд ухаж эхлэх болгов.

2 Мөн эдгээр шороон далан дээгүүр нь гуалингууд байв, тийм ээ, хотуудыг хүрээлүүлэн, хүнийхтэй адил өндөртэй гуалин тулгууруудыг босгох болгов.

3 Мөн тэрээр тэдгээр тулгууруудын оройгоор үзүүрт шонгуудыг хүрээлэн байрлуулах болгов; мөн тэдгээр нь бат бэх бөгөөд өндөр байв.

4 Мөн тэр тэдгээр шонгуудын дээрээс ажиглах

цамхгуудыг баригдах болгож, мөн леменчүүдийн чулуу мөн сумнууд тэднийг гэмтээж чадахгүйн тулд тэрээр хориглох байруудыг тэдгээр цамхгууд дээр бариулах болгов.

5 Мөн тэдгээр нь тэд өөрсдийн хүслийн мөн өөрсдийн хүчний дагуу дээрээс нь чулуу хаяж, мөн хотын хананы дэргэд ойртохоор завдсан түүнийг алж болохуйцаар бэлтгэгдсэн байв.

6 Тийн бүх нутгийн хот болгоныг хүрээлүүлэн, дайснуудынхаа халдлагын эсрэг хориглолтуудыг Моронай бэлтгэсэн байлаа.

7 Мөнхүү улиран тохиох дор Моронай их цэргээ дорнодын аглаг буйд тийш одох болгов; тийм ээ, мөн тэд явж мөн дорнодын аглаг буйдад байсан бүх леменчүүдийг, Зарахемла нутгийн өмнөд дэх өөрсдийнх нь нутагт хөөв.

8 Мөн Нифайн нутаг дорнодын тэнгисээс өрнөдийг хүртэл чигээрээ шулуун үргэлжилж байв.

9 Мөнхүү улиран тохиох дор Моронай бүх леменчүүдийг өөрсдийнх нь эзэмшил нутгуудын умард дахь, дорнод аглаг буйдаас зайлуулсны дараа, тэрээр Зарахемла нутаг дахь мөн эргэн тойрных нь нутгийн оршин суугчдыг дорнын аглаг буйд тийш бүр тэнгисийн эргийг хүртэл явуулж, мөн уг нутгийг эзэмших болгов.

10 Мөн түүнчлэн тэрээр өөрсдийн эзэмшлүүдийн хил дээр өмнөдөд их цэргийг

байрлуулж, мөн их цэрэг мөн ард түмнээ дайснуудынхаа гараас хамгаалж болохын тулд “бэхлэлт босгож болгов.

11 Мөн тийн тэрээр леменчүүдийн дорнын аглаг буйдад, тийм ээ, мөн түүнчлэн өрнөдөд байх тэр бүх бэхлэлтийг тусгаарлаж, нифайчууд мөн леменчүүдийн хооронд, Зарахемла нутаг мөн Нифайн нутгийн хооронд, өрнийн тэнгисээс Сидон голын эхийн дэргэдүүр орших хилийн бэхлэлтийг барив — нифайчууд умардын бүх нутгийг, тийм ээ, бүр Өгөөмөр нутгийн умардад байсан бүх нутгийг тааллынхаа дагуу эзэмшсэн бөлгөө.

12 Тийн Моронай, өөрийнх нь ажлын тэдэнд авчрах хамгаалалтын баталгаатайн учир өдөр бүр өсөн нэмэгдэх их цэрэгтэйгээ, тэд эзэмшлийн нутгууд дээр нь хүч нөлөөгүй байхын тулд леменчүүдийн хүч болоод чадлыг эзэмшлийнхээ нутгуудаас тусгаарлахыг эрэлхийлсэн аж.

13 Мөнхүү улиран тохиох дор нифайчууд нэгэн хотын суурийг эхлэв, мөн тэд хотын нэрийг Моронай хэмээв; мөн энэ нь дорнын тэнгисийн эрэгт байв; мөн энэ нь леменчүүдийн эзэмшлүүдийн хилийн шугамын ойролцоо өмнөдөд байлаа.

14 Мөн түүнчлэн тэд Моронай хот мөн Аарон хот хоёрын хооронд Аарон мөн Моронайн хилүүдийг нэгтгэн

нэгэн хотын суурийг эхлэв; мөн тэд уг хотын, өөрөөр хэлбэл уг нутгийн нэрийг Нифайха хэмээв.

15 Мөн түүнчлэн тэд мөнхүү онд умардад олон хот, умардад тэнгисийн хөвөөнд байсан тэр, нэг хотыг нэгэн тодорхой маягаар барьж Лихай гэж тэд нэрлэв.

16 Мөн тийн хорьдугаар он төгсөв.

17 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хориннэгдүгээр оны эхэнд Нифайн хүмүүс эдгээр хөгжингүй нөхцөлд байв.

18 Мөн тэд үлэмж дэгжин, мөн тэд үлэмж баян болов; тийм ээ, мөн тэд уг нутагт өнөржиж мөн хүчирхэг болов.

19 Мөн хүмүүний үрсэд өөрийн бүх үгсийг гүйцэлдүүлэхдээ Их Эзэний бүх хэргүүд хичнээн нигүүлсэнгүй хийгээд шударга болохыг бид тийн харлаа; тийм ээ, Лихайд түүний ярьсан үгс батлагдсаныг бүр энэ цагт бид болгоож чадна, өгүүлсэн нь:

20 Чи болон чиний үрс адислагдсан болой; мөн тэд адислагдах болно, тэд миний зарлигуудыг дагахын хэрээр уг нутагт дэгжих болно. Гэвч санагтун, тэд миний зарлигуудыг дагахгүй байхын хэрээр тэд Их Эзэний дэргэдээс “тусгаарлагдах болно.

21 Мөн эдгээр амлалтууд Нифайн хүмүүст батлагдсаар байсныг бид харав; учир нь тэдний дээрх өөрсдийнх нь

дайнүүд хийгээд устгалуудыг авчирсан нь тэдний дунд байсан тэрхүү хэрүүлүүд мөн зөрчлүүд, тийм ээ, тэдний аллагууд, мөн тэдний тонуулууд, тэд хуурамч шүтээнийг шүтдэг байсан нь, тэдний садар самуун, мөн жигшүүрт хэргүүд юм.

22 Мөн Их Эзэний зарлигуудыг дагахад итгэлтэй байсан тэд, өөрсдийнх нь мянга мянган ёс бус ах дүүс боолчлолд байхад, эсвээс илдэнд эрсдэхэд, эсвээс итгэлгүйдээ бууран доройтож, мөн леменчүүдтэй хутгалдсан үед цаг үргэлж чөлөөлөгдөж байв.

23 Гэвч болгоогтун Нифайн хүмүүсийн дунд, Нифайн өдрүүдээс, тийм ээ, энэ цаг үеэс хойш, шүүгчдийн засаглалын хориннэгдүгээр онд Моронайн өдрүүдээс илүү “аз жаргалтай үе хэзээ ч байсангүй.

24 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын хорин хоёрдугаар он; тийм ээ, мөн хорин гуравдугаар он ч түүнчлэн амар амгаланд төгсөв.

25 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын хорин дөрөвдүгээр оны эхэнд ч, хэрэв тэдний дунд Лихайн хилтэй нийлсэн, хоёул тэнгисийн хөвөөнд байсан Лихайн нутгийн мөн Мориантоны нутгийн талаарх “зөрчилдөөн байгаагүй сэн бол, Нифайн хүмүүсийн дунд түүнчлэн амар амгалан байх байв.

26 Учир нь болгоогтун, Мориантон нутгийг эзэмш-

сэн хүмүүс Лихай нутгийн хэсгийг нэхэмжлэв; тиймийн тул тэдний хооронд ширүүн зөрчилдөөн болж эхлэв, үүний хэрээр Мориантоны хүмүүс ах дүүсийнхээ эсрэг зэвсэг агсан, мөн тэднийг илдээр хөнөөхөөр тэд шийдэмгий байв.

27 Гэвч болгоогтун, Лихай нутгийг эзэмшсэн хүмүүс Моронайн буудалд зугтан очиж, мөн түүнээс тусламж хүсэв; учир нь болгоогтун тэдний буруу биш байлаа.

28 Мөнхүү улиран тохиох дор Мориантон гэдэг хүнээр удирдуулж асан Мориантоны хүмүүс, Лихайн хүмүүс Моронайн буудалд зугтаж очсоныг олж мэдээд, тэд Моронайн их цэрэг өөрсөд дээр нь ирэн мөн өөрсдийг нь устгах вий хэмээн үлэмж айж байв.

29 Тиймийн тул Мориантон тэд их нуурууд олонтой, умард хэсгийн нутагт зугтан очиж, мөн умард хэсэгт байсан нутгийг эзэмшилдээ авна хэмээх бодлыг тэдний зүрх сэтгэлд төрүүлэв.

30 Мөн болгоогтун, тэд энэ төлөвлөгөөг ажил болгох бай, (харамслын шалтгаан болох байсан үүнийг) гэвч болгоогтун, Мориантон омог ихтэй хүн байсан учир, тиймийн тул тэрээр шивэгчингүүдийнхээ нэгэнд уурлаж, мөн тэр түүнийг дайрч мөн түүнийг ихэд зодов.

31 Мөнхүү улиран тохиох дор сайхь бүсгүй зугтаж, мөн

Моронайн буудалд ирж, мөн Моронайд уг хэргийн талаар, мөн түүнчлэн умард нутагт зугтах гэсэн тэдний санааны талаар бүх зүйлийг Моронайд хэлэв.

32 Эдүгээ болгоогтун, тэд Мориантоны үгсийг дуулж мөн түүний хүмүүстэй нэгдэж, мөн тийн тэрээр уг нутгийн тэдгээр хэсгүүдийг эзэмшилдээ авах вий хэмээн Өгөөмөр нутагт байсан хүмүүс, чухамдаа бол Моронай айж байлаа, тэгвээс Нифайн хүмүүсийн дундах их уршгийн, тийм ээ, тэдний “эрх чөлөөг унагахад хүргэх уршгийн суурь тавигдах байсан бөлгөө.

33 Тиймийн тул Моронай их цэргийг, буудлынх нь хамт, тэд умард нутаг тийш зугтахыг зогсоохоор Мориантоны хүмүүсийг амдуулахаар илгээв.

34 Мөнхүү улиран тохиох дор тэднийг “Эзгүйрлийн нутгийн хилд ирэх хүртэл тэд тэднийг гүйцсэнгүй; мөн тэд умард нутагт хүргэх, тийм ээ, тэнгисийн дэргэдүүр, дорнодод мөн өрнөдөд тэнгисийн дэргэдүүрх нарийн гарцын тэнд тэднийг амдсан ажээ.

35 Мөнхүү улиран тохиох дор Моронайгаар илгээгдсэн, Тианкам гэдэг нэртэй хүнээр удирдагдсан тэрхүү их цэрэг Мориантоны хүмүүстэй тулгарав; мөн Мориантоны хүмүүс маш их зөрүүд байв, (түүний ёс бус мөн түүний

зусар үгсээр тэд өдөөгдсөн учир) ийнхүү тэдний дунд Тианкам Мориантоныг алж мөн их цэргийг нь ялж, мөн тэднийг хоригдлууд болгон баривчилж, мөн Моронайн буудалд эргэж ирсэн тэрхүү тулаан эхэлсэн бөлгөө. Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин дөрөв дэх он тийн төгсөв.

36 Мөн Мориантоны хүмүүс тийн буцаан авчрагдав. Мөн тэд энхийг сахих гэрээ хиймэгц, тэд Мориантоны нутагт дахин суурьшуулагдаж, мөн Лихайн хүмүүс болон тэдний дунд эвлэрэх ёс гүйцэтгэгдэв; мөн тэд түүнчлэн нутагтаа дахин суурьшуулагдав.

37 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүст тэдний энх амгалан сэргээгдсэн тус онд, Бурханы өмнө төгс зөв шударгаар шүүлтийн суудлыг эзэлсэн тэр хоёр дахь ерөнхий шүүгч Нифайха нас барав.

38 Гэсэн хэдий ч, Алма болон түүний эцэг өвгөдөөр хамгийн ариун нандин хэмээн үнэлэгдсэн тэдгээр цэдгүүд мөн тэдгээр зүйлүүдийг эзэмшүүлэх Алмагийн хүслээс тэрээр татгалзсан ажээ; тиймийн тул Алма тэдгээрийг өөрийн хүү, Хиламаны дээр шилжүүлэв

39 Болгоогтун, улиран тохиох дор Нифайхагийн хүү эцгийнхээ оронд шүүлтийн суудлыг эзлэхээр томилогдов; тийм ээ, зөв шударгаар шүүх, мөн ард олны энх

амгалан хийгээд эрх чөлөөг сахин хамгаалах, мөн Их Эзэн Бурханаа шүтэн бишрэх ариун нандин боломжийг нь тэдэнд олгох, тийм ээ, өөрийн бүх өдрүүдэд Бурханы зорилгыг дэмжиж, хадгалахаар, тэрчлэн ёс бусыг үйлдэгчдийг гэмт хэргүүдийнх нь дагуу шударга ёсонд авчрах тангараг өргөн мөн ариун ёслолыг үйлдэж тэрээр ерөнхий шүүгч бөгөөд ард олны дээрх захирагчаар томилогдов.

40 Эдүгээ болгоогтун, түүний нэр Пахоран байв. Мөн Пахоран эцгийнхээ суудлыг эзэлж, мөн Нифайн хүмүүсийн дээрх өөрийн засаглалыг хорин дөрөвдүгээр оны төгсгөлд эхлүүлэв.

БҮЛЭГ 51

Хааныг хүсэгч хүмүүс хуулийг өөрчлөхөөр мөн хаантай байхаар эрэлхийлэв—Пахоран болон чөлөөт байдлыг хүсэгч хүмүүс ард түмний саналаар дэмжигдэв—Улс орноо дэмжихийг эсвээс үхэлд хүргэгдэхийг хааныг хүсэгч хүмүүст Моронай албадав—Амаликая болон леменчүүд бэхлэгдсэн олон хотыг эзлэв—Тианкам леменчүүдийн дайралтыг няцааж, Амаликаяг майханд нь алав. Ойролцоогоор мээ 67–66 он.

Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин тав дахь оны эхэнд, тэд Лихайн хүмүүс мөн Мориантоны хүмүүсийн хооронд

нутгийнх нь талаар амгаланг тогтоогоод, мөн хорин тав дахь он энх амгаланд эхэлсний дараа;

2 Гэсэн хэдий ч, тэд уг нутагдахь нийт энх амгаланг удаан сахьсангүй, учир нь ерөнхий шүүгч Пахораны талаар хүмүүсийн дунд зөрчилдөөн байж эхлэв; учир нь болгоогтун, хуулийн цөөн тодорхой зүйлүүд өөрчлөгдөх ёстой хэмээн хүссэн хэсэг хүмүүс байв.

3 Гэвч болгоогтун, Пахоран хуулийг өөрчлөх бас өөрчлөгдөхыг ч зөвшөөрсөнгүй; тиймийн тул, тэрээр хуулийг өөрчлөх тухай өөрсдийн саналыг айлтгалтайгаа илгээсэн тэднийг сонссонгүй.

4 Тиймийн тул, хуулийг өөрчлүүлэх хүсэлтэй тэд түүнд уурлаж, мөн түүнийг уг нутаг даяарх ерөнхий шүүгч байхыг болиулахыг хүсэв; тиймийн тул уг хэргийн талаар халуухан тэмцэл өрнөв, гэвч цус урсгахад хүрсэнгүй.

5 Мөнхүү улиран тохиох дор Пахораныг шүүгчийн суудлаас унагаах хүсэлтэй байсан тэд хааныг хүсэгч хүмүүс хэмээн нэрлэгдсэн ажгуу, учир нь тэд чөлөөт засгийг түлхэн унагаж мөн уг нутаг даяар хааныг тогтоох байдлаар хууль өөрчлөгдөхийг хүсч байв.

6 Мөн Пахораныг уг нутгийн дээрх ерөнхий шүүгчээр үлдээхийг хүссэн тэд өөрсдийн дээр чөлөөт байдлыг хүсэгч хүмүүс хэмээх нэр авчээ; мөн тэдний дунд хагарал ийм байв, учир нь чөлөөт байдлыг хүсэгч хүмүүс өөрсдийн

эрхүүд хийгээд өөрсдийн шашин шүтлэгийн боломжуудаа чөлөөт засгаар батлан хамгаалуулахаар тангараглаж өөрөөр хэлбэл гэрээлсэн байв.

7 Мөнхүү улиран тохиох дор тэдний зөрчилдөөний энэхүү хэрэг хүмүүсийн саналаар таслагдсан ажээ. Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн санал чөлөөт байдлыг хүсэгч хүмүүсийн талд болж, мөн Пахоран шүүлтийн суудалд хэвээр үлдсэн нь Пахораны ах дүүс хийгээд түүнчлэн эрх чөлөөг хүсэгч хүмүүсийн олных нь дунд их баярыг авчирч, мөн тэд түүнчлэн хааныг хүсэгч хүмүүсийг дуугүй болгов, тиймээс тэд эсэргүүцэж зүрхэлсэнгүй харин эрх чөлөөний хөдөлгөөнийг хадгалан хамгаалахаас аргагүй болов.

8 Эдүгээ тэдгээр хаадыг таалагсад “дээд зиндааныхан байв, мөн тэд хаад байхыг эрэлхийлэв; мөн хүмүүсийг захирах хүч чадал, эрх мэдлийг эрэлхийлэх тэднээр тэд дэмжигдэв.

9 Гэвч болгоогтун энэ нь Нифайн хүмүүсийн дунд тиймэрхүү зөрчилдөөн байхад аюултай үе байв; учир нь болгоогтун, нифайчуудын хүмүүсийн эсрэг, леменчүүдийн хүмүүсийн зүрх сэтгэлийг Амаликая дахин өдөөн хатгасан ажгуу, мөн тэрээр нутгийнхаа бүх хэсгээс цэргүүдийг нэгтгэн цуглуулж, мөн тэднийг зэвсэглэн, мөн

дайнд байдгаараа хичээнгүйлэн бэлтгэж байв; учир нь тэр Моронайн цусыг уухаар “ам алдсан бөлгөө.

10 Гэвч болгоогтун, бид түүний амлалт яаруу хийгдсэнийг харах болно; гэсэн хэдий ч, тэрбээр өөрийгөө мөн их цэргээ нифайчуудын эсрэг тулалдаанд орохоор бэлтгэжээ.

11 Эдүгээ түүний их цэрэг, нифайчуудын гараар алагдсан олон мянгын учир урьд байсан шигээ тийм агуу байсангүй; гэвч тэдний их хохиrol байсан хэдий ч, Амаликая их цэргийг гайхалтай олноор нэгтгэн цуглуулсан байв, үүний хэрээр тэр Зарахемла нутаг уруу очихоос айсангүй.

12 Тийм ээ, бүр Амаликая өөрөө леменчүүдийн тэргүүнд уруудан ирэв. Мөн энэ нь шүүгчдийн засаглалын хорин тав дахь онд байв; мөн энэ нь тэд өөрсдийн ерөнхий шүүгч Пахораны талаарх зөрчилдөөний хэргийг шийдэж эхэлсэнтэй нэгэн үед тохиов.

13 Мөнхүү улиран тохиох дор хааныг хүсэгч хүмүүс гэж нэрлэгдсэн тэдгээр хүмүүс леменчүүд тэдний эсрэг тулалдахаар ирж явааг сонсоод, тэд зүрх сэтгэлдээ баяртай байв; мөн зэвсэг барихаас татгалзав, учир нь тэд ерөнхий шүүгчид, мөн түүнчлэн “эрх чөлөөний хүмүүст, тэд улс орноо өмгөөлөхөөр зэвсэг барихааргүй тийм ихээр хилэгнэсэн байв.

14 Мөнхүү улиран тохиох дор Моронай үүнийг хараад, мөн түүнчлэн леменчүүд нутгийн хилд орж буйг хараад, хамгаалж үлдэхийн тулд тийм ихээр хөдөлмөрлөсөн тэдгээр хүмүүсийнхээ зөрүүдийн учир тэрээр үлэмж хилэгнэж байв; тийм ээ, тэрээр үлэмж хилэгнэж байв, түүний бодгаль тэдний эсрэг уурандаа багтарч байв.

15 Мөнхүү улиран тохиох дор тэр түүнээс үүнийг уншихыг, мөн тэдгээр тэрслэгчдийг улс орноо өмгөөлөхийг албадан эс бөгөөс үхэлд хүргэх мэдэл хүчийг өөрт нь (Моронайд) өгөхийг хүсэн, хүмүүсийн саналыг тээсэн айлтгалыг уг нутгийн эрх баригчид илгээв.

16 Учир нь хүмүүсийн дундах зөрчилдөөнүүд хийгээд тэрслэлүүдийг төгсгөх нь түүний анхны ажил байв; учир нь болгоогтун, энэ нь одоо хүртэл тэдний бүх устгалын шалтгаан байлаа. Мөнхүү улиран тохиох дор энэ нь хүмүүсийн саналын дагуу зөвшөөрөгдөв.

17 Мөнхүү улиран тохиох дор, хааныг хүсэгч хүмүүсийн эсрэг явж, тэдний бардамналыг мөн сурвалжит байдлыг унаган мөн тэднийг газартай тэгшлэх, эсвээс тэд зэвсэг барьж мөн эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжихийг албадахыг Моронай их цэрэгтээ зарлиглав.

18 Мөнхүү улиран тохиох дор их цэрэг тэдний эсрэг

давшин оржээ; мөн тэдний бардамналыг хийгээд сурвалжит байдлыг унагаж, үүний хэрээр тэд Моронайн хүмүүсийн эсрэг тулалдахаар дайны зэр зэвсгээ өргөмөгц тэд хиаран унаж, газартай тэгшлэгдсэн байв.

19 Мөнхүү улиран тохиох дор тэдгээр “тэрслэгсдээс илдээр хиар цохиулсан нь дөрвөн мянга байв; мөн тэдний удирдагчдаас тулалдаанд алагдаагүй нь баривчлагдаж мөн шоронд хаягдав, учир нь энэ үед тэдний шүүлтэд зориулах цаг байсангүй.

20 Мөн тэдгээр тэрслэгсдийн үлдсэн нь, илдээр доош газар цохигдохын оронд, эрх чөлөөний туган дор бууж өгөөд, мөн “эрх чөлөөний далбааг цамхгууд дээрээ мөн хотууддаа өргөхөөр, мөн улс орноо өмгөөлөхийн төлөө зэвсэг агсахаар албадуулагдав.

21 Мөн тийн Моронай хааныг хүсэгч хүмүүсийн төгсгөлийг тавьж, тиймээс хааныг хүсэгч хэмээх нэрээр нэрлэгдэх хэн ч үгүй болов; мөн тийн тэрээр сурвалжит цустай хэмээсэн тэдгээр хүмүүсийн зөрүүд хийгээд бардам занг төгсгөл болгов; харин тэд ах дүүсийнхээ адил өөрсдийгөө доош даруусгаж, мөн боолчлолоос эрх чөлөөтэй байхын тулд эрэлхэг зоригтойгоор тулалдахад албадуулагдав.

22 Болгоогтун, улиран тохиох дор “Моронай тийн

өөрийнхөө хүмүүсийн дундах дайнууд хийгээд зөрчилдөөнүүдийг зогсоож, мөн тэднийг амар амгалан болон соёл иргэншилд харьяалуулж, мөн леменчүүдийн эсрэг дайнд бэлтгэхээр журмуудыг бий болгож байх зуур, болгоогтун, леменчүүд тэнгисийн эргээр хиллэдэг байсан Моронайн нутагт орж ирсэн байв.

23 Мөнхүү улиран тохиох дор нифайчууд Моронай хотод хангалттай хүчирхэг байсангүй; тиймийн тул Амаликаа оlnыг алснаар тэднийг хөөв. Мөнхүү улиран тохиох дор Амаликаа хотын эзэмшлийг, тийм ээ, тэдний бүх бэхлэлт хамгаалалтын эзэмшлийг авчээ.

24 Мөн Моронай хотоос гарч зугтсан тэд Нифайха хотод ирэв; мөн түүнчлэн Лихай хотын хүмүүс нэгдэн цугларцгааж, мөн бэлтгэлийг базаан тэгээд леменчүүдийг тулалдаанд хүлээн авахад бэлэн болов.

25 Гэвч улиран тохиох дор Амаликаа Нифайха хотын эсрэг тулалдахаар леменчүүдийг явахыг зөвшөөрсөнгүй, харин тэднийг тэнгисийн эрэгт байлгаж, хот болгонд сахиж мөн өмгөөлүүлэхээр эрчүүдийг үлдээж байв.

26 Мөн тийн тэрээр одож, олон хот, Нифайха хотыг, мөн Лихай хот, мөн Мориантон хот, мөн Омнер хот, мөн Гид хот, мөн Мюлек хотыг, тэнгисийн эрэгт, дорнодод байсан

бүгдийг эзэмшилдээ авсаар цаашлав.

27 Мөн тийн леменчүүд Амаликаагийн башир аргаар, ийм тоо томшгүй ийм олон цэргээрээ олон хотыг эзэлж авав, тэр бүгд нь Моронайн “бэхлэлтүүдийн маягаар бат бэхээр бэхлэгдсэн байв; тэр бүгд леменчүүдэд хориглолт болов.

28 Мөнхүү улиран тохиох дор тэд нифайчуудыг өмнөө тууж мөн олныг нь алсаар Өгөөмөр нутгийн хилд жагсан очив.

29 Гэвч улиран тохиох дор Мориантоныг “алж мөн түүний хүмүүсийг зугтаж байхад нь амдсан Тианкамтай тэд тулгарав.

30 Мөнхүү улиран тохиох дор тэрээр, олон тооны их цэрэгтэйгээ хамт Өгөөмөр нутгийг, мөн түүнчлэн умард нутгийг эзэмшилдээ авч болно хэмээн жагсаж явахад нь түүнчлэн Амаликааг амдав.

31 Гэвч болгоогтун тэрээр Тианкам болон түүний хүмүүсээр буцаагдсанаар амжилтанд хүрсэнгүй, учир нь тэд агуу дайчид байв; учир нь Тианкамын хүн бүр нь леменчүүдээс хүч чадал хийгээд дайтах чадвараараа давуу байв, үүний хэрээр тэд леменчүүдийг давамгайлсан бөлгөө.

32 Мөнхүү улиран тохиох дор тэд тэднийг зовоож, үүний хэрээр тэд тэднийг бүр харанхуй болтол алав. Мөнхүү улиран тохиох дор Тианкам болон түүний хүмүүс

Өгөөмөр нутгийн хилийн тэнд майхнуудаа босгов; мөн Амаликая майхнуудаа тэнгисийн эргийн дэвсгэ дээрх хилийн тэнд босгов, мөн энэ маягаар тэд туугдсан ажээ.

33 Мөнхүү улиран тохиох дор шөнө ирэхэд, Тианкам болон түүний зарц сэмхэн гарч мөн шөнөөр явж, бас Амаликаягийн буудалд очив; мөн болгоогтун, тэд өдрийн хөдөлмөр бас халуунаас болж машинд ядарснаас тэд нойрондоо дийлдсэн байв.

34 Мөнхүү улиран тохиох дор Тианкам нууцаар хааны майханд сэмхэн орж, мөн зүрхэнд нь жад зоов; мөн тэрээр тэр даруй хааныг үхүүлсэн учир, тэрээр зарц нарыг нь сэрээсэнгүй.

35 Мөн тэрээр буудалдаа нууцаар буцаж ирэхэд, мөн болгоогтун, хүмүүс нь унтаж байв, мөн тэрбээр тэднийг сэрээж мөн хийсэн бүх зүйлээ тэдэнд хэлэв.

36 Мөн тэрбээр леменчүүд сэрж мөн тэдний зүг ирэхвий хэмээн их цэргээ бэлэн байлдалд оруулав.

37 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин тавдугаар он төгсөв; мөн тийн Амаликаягийн өдрүүд төгсөв.

БҮЛЭГ 52

Амморон леменчүүдийн хаан болж Амаликаяг залгамжлав— Моронай, Тианкам, мөн Лихай нар леменчүүдийн эсрэг ялгуусан

дайнд нифайчуудыг удирдав— Мюлек хот буцаан авагдаж, мөн зорам үндэстэн Иаков алагдав. Ойролцоогоор мээ 66–64 он.

Мөн эдүгээ, улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин зургадугаар онд, болгоогтун, эхний сарын эхний өдөр леменчүүд сэрээд, болгоогтун, Амаликая майхандаа үхсэнийг олов; мөн түүнчлэн тэд Тианкам тэр өдөртөө тэднийг дайлаар мордоход бэлэн буйг тэд үзэв.

2 Мөн эдүгээ, леменчүүд үүнийг үзээд айв; мөн тэд уг нутгийн умард тийш жагсан очих тухай бодлоо орхиж, мөн бүх их цэрэгтэйгээ Мюлек хотод ухарч, мөн бэхлэлтэндээ хамгааллыг эрэлхийлэв.

3 Мөнхүү улиран тохиох дор Амаликаягийн дүү уг хүмүүсийн дээр хаанаар тохоогдов; мөн түүний нэр Амморон байв; тийн хаан Амморон, Амаликая хааны дүү, түүний оронд засаглахаар тохоогдов.

4 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүмүүс цус урсгаснаар авсан хотуудаа хамгаалан хадгалахыг зарлиглав; учир нь тэд их цус алдалгүйгээр тэд ямар ч хотыг авагүй билээ.

5 Мөн эдүгээ, леменчүүд өөрсдийн авсан хотуудыг мөн эзэмшилдээ олж авсан уг нутгийн тэдгээр хэсгүүдийг хадгалан хамгаалахаар шийдсэнийг Тианкам харав; мөн түүнчлэн тэдний тооны асар олныг хараад, Тианкам бэхлэлтүүдэд нь тэднийг

довтлохыг оролдох нь зүйд нийцэхгүй хэмээн боджээ.

6 Гэвч тэрээр өөрийн хүмүүсийг эргэн тойронд нь, дайны тулд бэлтгэлүүдийг базааж буй мэтээр байлгаж байв; тийм ээ, мөн үнэндээ тэрээр хүрээлэн байх хэрмүүдийг “босгож мөн хориглох байруудыг бэлтгэснээр өөрийгөө тэднээс хамгаалахаар бэлтгэж байв.

7 Мөнхүү улиран тохиох дор Моронай олон тооны хүмүүсийг их цэргийг нь хүчирхэгжүүлэхээр илгээх хүртэл тэрээр тийн дайнд бэлтгэж байв.

8 Мөн түүнчлэн, тэрбээр гарт нь орсон бүх олзлогдогсдыг хадгалах ёстой хэмээх тушаалуудыг Моронай түүнд илгээв; учир нь леменчүүд олныг олзлон авсны хэрээр, тэрбээр леменчүүдэд олзлогдсон тэдний золиосонд леменчүүдээс олзлогдсон бүгдийг хадгалах ёстой хэмээсэн ажгуу.

9 Мөн леменчүүд уг газрыг эзэлж аваад тал бүрээс нь зовоох хүчийг олох вий хэмээн тэрээр түүнчлэн Өгөөмөр нутгийг бэхэлж, мөн умард нутаг тийш удирддаг “нарийн гарцыг хамгаалах ёстой хэмээх тушаалуудыг илгээжээ.

10 Мөн түүнчлэн тэрээр нутгийн уг хэсгийг хадгалан хамгаалахдаа итгэлтэй байж, мөн тэрээр гараас нь булаагдсан тэдгээр хотуудыг заль мэхээр эсвээс ямар нэгэн өөр аргаар буцаан авч магадын

тулд, уг хэсэгт леменчүүдийг цээрлүүлэх өөрийн хүч хүрэх боломж бүрийг эрэлхийлэхийг; мөн тэрбээр түүнчлэн леменчүүдийн гарт ороогүй байгаа тэдгээр эргэн тойрныхоо хотуудыг бэхлэн, хүчирхэгжүүлэхийг хүсэн Моронай түүнд илгээжээ.

11 Мөн тэрбээр түүнчлэн түүнд хэлэв, би чам дээр очмоор байна, гэвч болгоогтун, леменчүүд өрнийн тэнгисийн тэнд нутгийн хилд бидний дээр ирлээ; мөн болгоогтун, би тэдний эсрэг явна, тиймийн тул би чам дээр очиж чадахгүй нь.

12 Эдүгээ хаан (Амморон) Зарахемла нутгаас гарч одоод, мөн ахынхаа үхлийн талаар хатанд мэдүүлж, мөн маш олон тооны эрсийг нэгтгэн цуглуулж, нифайчуудын эсрэг өрнөд тэнгисийн дэргэдэх хил дээр давшин очсон байв.

13 Мөн тийн тэрээр нифайчуудыг зовоохыг, мөн тэдний хүчний нэг хэсгийг нутгийн уг хэсэг тийш дагуулахыг хичээж байв, тэгэхдээ түүнчлэн тэд ч нифайчуудыг дорнод тэнгисийн дэргэдэх хил дээр зовоохыг, мөн их цэргийнхээ хүчний дагуу хүч хүрэхийнхээ хэрээр нутгуудыг нь эзэмшилдээ авахыг тэрээр эзэлсэн хотуудаа захируулахаар үлдээсэн хүмүүстээ зарлиглажээ.

14 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин зургадугаар оны

төгсгөлд, тийн нифайчууд тэдгээр аюултай нөхцөлд байв.

15 Гэвч болгоогтун, улиран тохиох дор шүүгчдийн засаглалын хорин долдугаар онд, Тианкам, Моронайн тушаалаар — нутгийн өмнөд болон өрнөд хилийг хамгаалах их цэргийг байгуулж, мөн алдсан хотуудаа буцаан авахад Тианкамыг тэрээр өөрийн хүмүүсээр дэмжиж болохын тулд Өгөөмөр нутгийн зүг жагсан явж эхэлсэн буюу —

16 Мөнхүү улиран тохиох дор Тианкам Мюлек хотод дайралт хийж, мөн хэрэв энэ нь боломжтой байваас үүнийг буцаан авах тушаал хүлээн авчээ.

17 Мөнхүү улиран тохиох дор Тианкам Мюлек хотод дайралт хийх, мөн их цэргийнхээ хамт леменчүүдийн эсрэг давшин очих бэлтгэлүүдийг базаав; гэвч тэднийг бэхлэлтэндээ байхад нь дийлэх боломжгүйг тэр ойлгов; тиймийн тул тэрээр төлөвлөгөөгөө орхиж мөн Өгөөмөр хотод, тэрээр их цэрэгтээ хүч нэмж болно хэмээн, Моронайн ирэлтийг хүлээхээр буцаж ирэв.

18 Мөнхүү улиран тохиох дор Моронай их цэргийнхээ хамт Өгөөмөр нутагт, Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин долдугаар оны эцэст хүрч ирэв.

19 Мөн хорин наймдугаар оны эхэнд — леменчүүдийг тэдний эсрэг тулалдахаар гарч ирэхэд хүргэхийн тулд; эсвээс тэд тэднээс давуу талыг олж

мөн Мюлек хотыг дахин авч болно хэмээн тэднийг хориглолтоос нь ямар нэгэн аргаар залилж гаргахын тулд юу хийх ёстой талаар, Моронай болон Тианкам мөн ерөнхий ахмадуудаас олон нь дайны зөвлөлдөөн хийв.

20 Мөнхүү улиран тохиох дор Мюлек хотыг хамгаалж буй, леменчүүдийн их цэрэгт, нэрийг нь Иаков гэдэг байсан тэдний удирдагчид түүнийг цэргийнхээ хамт тэдэнтэй тулалдахаар уг хоёр хотын хоорондох талбай дээр гарч ирэхийг хүсэн элч нарыг тэд илгээв. Гэвч болгоогтун, Иаков, зорам үндэстэн байсан тэрээр, цэрэгтэйгээ талбай дээр тэдэнтэй тулалдахаар гарч ирсэнгүй.

21 Мөнхүү улиран тохиох дор Моронай, тэдэнтэй тэгш нөхцөлд байх газар тулалдах найдвар байсангүй, тиймийн тул, тэрээр леменчүүдийг хориглолтоос нь гаргахаар залилж болохын тулд төлөвлөгөөг зохиов.

22 Тиймийн тул тэрээр, Тианкамыг цөөн тооны эрсийг авч мөн тэнгисийн эргийн дэргэдүүр уруудан жагсаж явах болгов; мөн Моронай болон түүний их цэрэг, шөнөөр, аглаг буйдад, Мюлек хотын өрнөдөд жагсан очив; мөн ийн, маргааш нь, леменчүүдийн харуулууд Тианкамыг олж хараад, тэд гүүлдэж мөн үүнийг өөрсдийн удирдагч Иаковт хэлэв.

23 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн их цэрэг

тэдний тоо цөөн учир Тианкамыг тоогоороо дийлнэ хэмээн сэтгэж, Тианкамын эсрэг давшин очив. Мөн Тианкам леменчүүдийн их цэрэг түүний эсрэг гарч ирж буйг хараад тэнгисийн эргээр умард зүг ухарч эхлэв.

24 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд түүний зугтаж эхлэхийг хараад, тэд зоригжин мөн идэвхтэйгээр мөрдөн хөөв. Мөн Тианкам ийн тэднийг хоосон мөрдөж буй леменчүүдийг зайлуулан дагуулж байх зуур, болгоогтун, Моронай өөртэй нь хамт байсан их цэргийнхээ нэг хэсгийг хотод давшин орохыг, мөн үүнийг эзэмшилдээ авахыг зарлиглав.

25 Мөн тэд тийн үйлдэж, мөн хотыг хамгаалахаар үлдээгдсэн тэд бүгдийг, тийм ээ, тэдний өмнө дайны зэвсгээ буулгаснаас бусад бүгдийг нь алжээ.

26 Мөн тийн Моронай их цэргийнхээ нэг хэсгээр Мюлек хотыг эзэмшилдээ авав, тэгэх зуураа тэрээр үлдсэн хэсэгтэй нь тэд Тианкамыг мөрдсөн мөрдөлтөөсөө эргэж ирэхэд нь леменчүүдтэй тулахаар давшин одов.

27 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд Өгөөмөр хотын дэргэд очтолоо Тианкамыг мөрдөн хөөгөөд, мөн тэд Өгөөмөр хотыг хамгаалахаар үлдээгдсэн Лихай болон цөөн тооны их цэрэгтэй тулгарав.

28 Мөн эдүгээ болгоогтун,

леменчүүдийн ерөнхий ахмад нь Лихай өөрийн цэрэгтэй тэдний эсрэг ирэхийг үзээд, тэд Мюлек хотод хүрэхээс нь өмнө Лихай тэднийг гүйцэх вий хэмээн тэд ихэд тэвдэн зугтав; учир нь тэд давшилтынхаа улмаас ядарсан байхад, харин Лихайн эрс сэргэг байв.

29 Эдүгээ леменчүүд Моронай их цэрэгтэйгээ тэдний ард байсныг мэдсэнгүй; мөн тэдний айсан ганцхан юм нь Лихай болон түүний эрчүүд байв.

30 Эдүгээ Моронай болон түүний их цэрэгтэй тулгарах хүртэл нь Лихай тэднийг гүйцэх хүсэлгүй байлаа.

31 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд хол ухрахаасаа өмнө, нифайчуудаар, Моронайн эрсээр нэг талаасаа, мөн Лихайн хүмүүсээр, бүгд сэргэг хийгээд хүч чадал дүүрэн байсан тэднээр нөгөө талаасаа бүслэгдэв; харин леменчүүд урт удаан давшилтынхаа улмаас ядарсан байв.

32 Мөн тэд дайны зэвсгүүдээ хураалгах хүртэл тэдний зүг довтлохыг Моронай өөрийн хүмүүст зарлиг болгов.

33 Мөнхүү улиран тохиох дор “зорам үндэстэн асан Иаков тэдний удирдагч нь, түүнчлэн, мөн дийлдэшгүй зоригтой байсан учир, тэрбээр Моронайн эсрэг тулалдахаар леменчүүдийг үлэмж омогтойгоор удирдав.

34 Моронай тэдний явах замд

нь байсан учир, тиймийн тул Иаков тэднийг хөнөөж мөн Мюлек хотод хүрэх замаа гаргахаар шийдсэн байв. Гэвч болгоогтун, Моронай болон түүний эрс илүү хүчтэй байв; тиймийн тул тэд леменчүүдийн өмнө зам тавьж өгсөнгүй.

35 Мөнхүү улиран тохиох дор тэд аль аль талдаа үлэмж ширүүн тулалдав; мөн аль аль талд олон нь алагдав; тийм ээ, мөн Моронай шархдаж мөн Иаков алагдав.

36 Мөн арын хэсэгт явсан леменчүүд дайны зэвсгээ хураалгах болгосон тийм ширүүнээр тэднийг ар талаас Лихай хүчит эрчүүдтэйгээ шахав; мөн тэдний үлдсэн нь, ихэд балмагдсаны улмаас, хааш явах эсвэл хаашаа дайрахаа мэдэхгүй байв.

37 Эдүгээ Моронай тэдний балмагдсаныг хараад, тэр тэдэнд: Хэрэв та нар дайны зэвсгээ авчирч мөн тэдгээрийгээ хураалгавал, болгоогтун би та нарын цусыг урсгахаа болино хэмээв.

38 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд эдгээр үгсийг сонсоод алагдаагүй байсан бүх ерөнхий ахмадууд ирж мөн Моронайн хөлд дайны зэвсгүүдээ доош хаяж, мөн түүнчлэн өөрсдийн эрсээ ч нэгэн адилаар үйлдэх ёстой хэмээн зарлиг болов.

39 Гэвч болгоогтун, тэгэхгүй нь олон байв; мөн илднүүдээ хураалгаагүй тэд баривчлагдаж мөн хүлэгдэж, мөн дайны

зэвсгүүд нь тэднээс авагдав, мөн тэд ах дүүстэйгээ хамт Өгөөмөр нутаг тийш очихоор албадуулагдав.

40 Мөн эдүгээ баривчлагдсан олзлогдогсдын тоо алагдсан хүмүүсийн тооноос илүү, тийм ээ, аль аль талд нь алагдсан хүмүүсээс илүү гарчээ.

БҮЛЭГ 53

Лемен үндэсний олзлогдогсод Өгөөмөр хотыг бэхлэн хамгаалахад ашиглагдав—Нифайчуудын дундах тэрслэл леменчүүдэд ялалтын шалтгаан болов—Аммоны хүмүүсийн хоёр мянган залуу хөвгүүдийн захиргааг Хиламан авав. Ойролцоогоор мээ 64–63 он.

Мөнхүү улиран тохиох дор тэд хоригдол леменчүүдийн дээр харуулуудыг тавьж, мөн тэднийг явж мөн өөрсдийнхөө үхэгсдийг, тийм ээ, мөн түүнчлэн алагдсан нифайчуудын шарилыг оршуулахыг албадав; мөн Моронай тэднийг ажлаа хийж байх үеэр харгалзах эрсийг тэдний дээр байрлуулав.

2 Мөн Моронай Лихайтай хамт Мюлек хотод очиж мөн хотын захиргааг авч мөн Лихайд үүнийг өгөв. Эдүгээ болгоогтун, энэхүү Лихай түүний бүх тулалдаануудаас ихэнхэд нь Моронайтай хамт байсан тэр хүн байв; мөн тэр Моронайтай “адил эр байв. Мөн тэд нэг нэгнийнхээ аюулгүй байдалд баясдаг

байв; тийм ээ, тэд нэг нэгэндээ хайрлагдсан, мөн түүнчлэн Нифайн бүх хүмүүсээр хайрлагдсан ажгуу.

3 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд өөрсдийн үхэгсэд мөн түүнчлэн нифайчуудын үхэгсдийг оршуулж дуусгасныхаа дараа, тэд буцаж Өгөөмөр нутагт хүргэгдэв; мөн Тианкам, Моронай тушаалаар тэднийг Өгөөмөр нутгийг, үнэндээ бол тэр хотыг хүрээлэх шуудууг ухахаар хөдөлмөрлөж эхлэх болгов.

4 Мөн тэрээр тэднийг шуудууны доторх эрэг дээгүүр гуалингаар “хашлага барих болгов; мөн тэд шуудуунаас шороог ухаж гуалин хашлагыг манаж овоолов; мөн гуалин мөн шороогоор үлэмж өндөр бат бэх ханаар Өгөөмөр хотыг хүрээлэх хүртэл тэд тийн леменчүүдийг хөдөлмөрлүүлэв.

5 Мөн энэ хот хойшид үлэмж бат бэх байхаар болгогдов; мөн энэ хотод; тийм ээ, бүр тэд, тэдний өөрсдийнх нь гараар бариулахаар албадагдсан ханын дотор леменчүүдийн олзлогдогсдыг харгалзаж байв. Эдүгээ Моронай леменчүүд хөдөлмөрлөхийг албадан шаардсан ажээ, учир нь тэднийг хөдөлмөрлөж байхад харгалзахад амар байв; мөн леменчүүдийн дээр дайралт хийх үед бүх хүчээ байлгахыг тэрээр хүсэн аж.

6 Мөнхүү улиран тохиох дор тийн Моронай леменчүүдийн

их цэргээс хамгийн хүчирхэг нэгний дээр ялалтыг олж, мөн Нифайн нутаг дахь леменчүүдийн хамгийн бат бэх бэхлэлтийн нэгэн болох Мюлек хотыг эзэмшилдээ авчээ; мөн тийн тэрээр олзлогдогсдыг хадгалах хориглолтыг түүнчлэн барьсан байв.

7 Мөнхүү улиран тохиох дор тэр жилдээ тэрбээр леменчүүдтэй тулалдахаар дахин оролдсонгүй, гэвч тэрбээр өөрийн хүмүүсийг дайнд бэлтгүүлж, тийм ээ, мөн түүнчлэн эхнэр мөн хүүхдүүдээ өлсгөлөн хийгээд зовлонгоос ангижруулж, мөн их цэргийнхээ хүнсийг хангаад тийм ээ, мөн түүнчлэн леменчүүдийн эсрэг хамгаалах бэхлэлтүүдийг хийхээр ажиллуулав.

8 Мөн эдүгээ улиран тохиох дор тэдний дунд тэрслэлийг бий болгосон тэр, нифайчуудын дундах зарим хуйвалдааны улмаас Моронайг эзгүй байх зуур, өрнөд тэнгисийн дэргэд, өмнөдөд, леменчүүдийн их цэргийнхэн нифайчуудын зарим газрыг эзэлсэн байв, тийм ээ, үүний хэрээр тэд нутгийн тэр хэсэг дэх хэд хэдэн хотыг эзэмшилдээ авсан байлаа.

9 Мөн тийн өөрсдийнх нь дундах алдсын учир, тийм ээ, өөрсдийнх нь дундах тэрслэл хийгээд хуйвалдаануудын учир тэд хамгийн аюултай нөхцөл байдалд тавигдав.

10 Мөн эдүгээ болгоогтун, Аммоны “хүмүүсийн талаар,

эхэндээ, леменчүүд байсан тэдний талаар хэлэх зарим зүйл надад байна; харин Аммон болон түүний ах дүүсээр үнэндээ бол Бурханы хүч мөн үгээр тэд Их Эзэнд ^бхөрвүүлэгдсэн байв; мөн тэд Зарахемла нутаг уруу авчрагдаж, мөн тэр үеэс нифайчуудаар хамгаалагдсаар ирсэн билээ.

11 Мөн өөрсдийн тангаргийн учир тэд ах дүүсийнхээ эсрэг зэр зэвсэг агсах нь хориглогдсон байв; учир нь тэд дахин “хэзээ ч цус урсгахгүй хэмээн тангараг өргөсөн байв; мөн тангаргийнхаа дагуу тэд мөхөх байсан бөлгөө; тийм ээ, Аммон болон түүний ах дүүсийнх тэдэнд хандуулсан өрөвч сэтгэл хийгээд үлэмжийн их хайр байгаагүй сэн бол тэд өөрсдийгөө ах дүүсийнхээ гарт орохыг тэвчих байлаа.

12 Мөн энэхүү шалтгааны улмаас тэд Зарахемлагийн нутагт авчрагдав; мөн тэр үеэс тэд Нифайчуудаар “хамгаалагдсаар ирсэн бөлгөө.

13 Гэвч улиран тохиох дор тэд өөрсдийнх нь төлөө нифайчуудын үүрдэг аюулыг хийгээд олон зүдрэл хийгээд бэрхшээлүүдийг хараад, тэд нинжин сэтгэлээр догдолж мөн улс орноо хамгаалахад зэр зэвсэг агсахыг “хүсч байв.

14 Гэвч болгоогтун, тэд дайны зэвсгээ агсах гэж байх үед

Хиламан болон түүний ах дүүсийн ятгалганд автав, учир нь тэд өргөсөн тэрхүү “тангаргаасаа бараг л ^бняцах нь холгүй байв.

15 Мөн тэд ийн үйлдсэнээс сүнсээрээ мөхөх вий хэмээн Хиламан айв; тиймийн тул энэхүү гэрээнд орсон тэд бүгд энэ цагт ах дүүсийнхээ аюултай нөхцөл байдал дахь зүдгүүрүүдийг туулахыг нь харахаар албадуулагдав.

16 Гэвч болгоогтун, улиран тохиох дор дайснуудынхаа эсрэг өөрсдийгөө хамгаалахаар дайны зэвсгүүдээ агсахгүй гэсэн гэрээнд ороогүй олон хөвгүүд тэдэнд байв; тиймийн тул энэ цагт тэд, зэр зэвсэг агсах боломжтой болгон нь өөрсдөө нэгдэн цугларч, мөн тэд өөрсдийгөө нифайчууд гэж нэрлэв.

17 Мөн тэд нифайчуудын эрх чөлөөний төлөө тулалдах, тийм ээ, амиа золих байсан ч уг нутгийг хамгаална гэсэн гэрээнд оржээ; тийм ээ, бүр тэд “эрх чөлөөгөө хэзээ ч тавьж өгөхгүй, харин нифайчуудыг мөн өөрсдийгөө боолчлолоос хамгаалахаар тэд ямар ч нөхцөлд тулалдах болно хэмээн гэрээ хийцгээв.

18 Эдүгээ болгоогтун, энэхүү гэрээнд орж мөн улс орноо хамгаалахаар дайны зэвсгээ агссан нь тэдгээр залуу эрсээс хоёр мянга байв.

19 Мөн эдүгээ болгоогтун, тэд урьд нь ч нифайчуудад

10б Алма 23:8–13.

11а Алма 24:17–19.

12а Алма 27:23.

13а Алма 56:7.

14а су Тангараг.

б Тоол. 30:2.

17а Алма 56:47.

су Эрх чөлөө.

хохирол байгаагүйн адилаар, эдүгээ тэд энэ үед ч түүнчлэн агуу их дэм болов; учир нь тэд дайны зэвсгүүдээ агсаж, мөн Хиламаныг өөрсдийн удирдагч байхыг хүсэв.

20 Мөн тэд бүгд залуу эрс мөн тэд “зориг, мөн түүнчлэн хүч чадал хийгээд эрч хүчээрээ үлэмж баатарлаг байв; гэвч болгоогтун, энэ нь бүгд бус — тэд итгэж даалгасан ямар ч зүйлд цаг ямагт үнэнч эрс байлаа.

21 Тийм ээ, тэд үнэн мөн чанд байдлын эрс байв, учир нь тэд Бурханы зарлигуудыг дагахыг мөн түүний өмнө зөв шударгаар “алхахыг заалгасан байв.

22 Мөн эдүгээ улиран тохиох дор “хоёр мянган залуу цэргүүдийнхээ тэргүүнд нь Хиламан, өрнөд тэнгисийн дэргэдэх өмнөд нутгийн хил дээр буй хүмүүсийг дэмжихээр жагсан одов.

23 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин найм дахь он тийн төгсөв.

БҮЛЭГ 54

Амморон Моронай нар хоригдлуудыг солилцохоор хэлэлцэв — Леменчүүдийг буцаж гарахыг мөн үхлийн дайралтуудаа болихыг Моронай шаардав — Нифайчуудыг зэр зэвсгээ хаяж, леменчүүдийн харъяат болохыг

Амморон шаардав. Ойролцоогоор мээ 63 он.

Мөнхүү эдүгээ улиран тохиох дор шүүгчдийн засаглалын хорин есдүгээр оны эхэнд, “Амморон хоригдлуудыг солилцохыг хүсэн тэрээр Моронайд илгээв.

2 Мөнхүү улиран тохиох дор Моронай энэ саналд үлэмж баясмаар санагдаж, учир нь тэрээр лемен үндэсний хоригдлуудыг тэтгэхийн тулд зарцуулж байгаа хүнсийг өөрийнхөө хүмүүсийг тэтгэхийн төлөө байлгахыг хүсчээ; мөн түүнчлэн тэрээр их цэргээ хүчирхэгжүүлэхийн тулд өөрийнхөө хүмүүсийг хүсч байв.

3 Эдүгээ леменчүүд олон эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийг олзолсон байв, харин Моронайн хоригдлуудын, өөрөөр хэлбэл Моронайн олзолсон хоригдлуудын дунд нэг ч эмэгтэй хүн бас хүүхэд байсангүй; тиймийн тул Моронай нифай үндэсний аль болох олон хоригдлыг леменчүүдээс арга мэхээр авахаар шийдэв.

4 Тиймийн тул тэрээр захидал бичиж, мөн Моронайн захидлыг авчирсан Аммороны зарцаар үүнийгээ илгээв. Эдүгээ Амморонд бичсэн түүний үгс нь эдгээр болой, өгүүлсэн нь:

5 Болгоогтун, Амморон, миний хүмүүсийн эсрэг та

20a су Зориг,
Зоригтой,
б су Зарчимч байдал.

21a су Алхах,
Бурхантай хамт
алхах.

22a Алма 56:3–5.
54 1a Алма 52:3.

нарын хийсэн, өөрөөр хэлбэл “ахын тань тэдний эсрэг үйлдсэн, мөн түүний үхлийн дараа ч одоо хүртэл та нар үргэлжлүүлэхээр хатуу шийдсэн энэхүү дайны талаар зарим зүйлийг би танд бичиж байсан билээ.

6 Болгоогтун, Бурханы “шударга ёсны талаар, мөн та нар наманчилж мөн их цэргээ өөрсдийнхөө нутагт, өөрөөр хэлбэл Нифайн нутаг болох, өөрсдийн эзэмшлийн нутагтаа буцаахгүй аваас та нарын дээр буухад бэлэн байгаа түүний бүхнийг чадагч хилэнгийн илдний талаар зарим зүйлийг би та нарт яримаар байна.

7 Тийм ээ, хэрэв та нар тэдгээрийг сонсох чадалтай сан бол би эдгээр зүйлийг та нарт хэлэх сэн; тийм ээ, та нар наманчилж мөн үхлийн зорилгуудаасаа няцаж мөн их цэргэтэйгээ нутагтаа буцахгүй аваас тань шиг мөн ах тань шиг тийм “алуурчдыг хүлээн авахаар хүлээх тэрхүү аймшигт ⁶тамын талаар би танд хэлмээр байна.

8 Гэвч та нар эдгээр зүйлийг нэгэнтээ эсэргүүцсэн, мөн Их Эзэний хүмүүсийн эсрэг тулалдсан учир, тэрчлэн би та нарыг үүнийг дахин хийх болно хэмээн бодож болох юм.

9 Мөн эдүгээ болгоогтун, бид та нарыг хүлээж авахад бэлтгэсэн буюу; тийм ээ, мөн

та нар зорилгуудаасаа няцахгүй аваас, болгоогтун, өөрсдийнхөө эсэргүүцсэн тэр Бурханы хилэнг, өөрсдийгөө бүрмөсөн устгалд хүртэл та нар доош өөрсөд дээрээ татан авчрах болно.

10 Гэвч, Их Эзэн амьдын адил, та нар буцахгүй аваас бидний их цэрэг та нарын дээр очих болно, мөн та нар удалгүй үхлээр зочлогдох болно, учир нь бид хотуудаа мөн нутгаа хадгалах болно; тийм ээ, мөн бид Бурханыхаа зорилгыг мөн шашнаа хадгалан хамгаалах болно.

11 Гэвч болгоогтун, би эдгээр зүйлийн талаар танд ярих нь дэмий хоосон хэмээн надад санагдана; өөрөөр хэлбэл та “тамын хүүхэд лугаа адил надад санагдана; тиймийн тул нэг хоригдлын төлөө та нар нэг эрийг түүний эхнэр мөн хүүхдүүдийг нь чөлөөлж ирүүлэх нөхцөлөөс бусдаар бол, би хоригдлуудыг солилцохгүйг танд хэлснээр захидлаа дуусгая; хэрэв та нар энэ нөхцөлийн дор үүнийг хийх аваас, би солилцох болно.

12 Мөн болгоогтун, хэрэв та нар үүнийг хийхгүй бол, би их цэргэтэйгээ та нарын эсрэг очих болно; тийм ээ, бүр би эмэгтэйчүүдээ мөн хүүхдүүдээ ч зэвсэглэх болно, мөн би та нарын эсрэг очиж, мөн та нарыг бүр бидний “анхны өв байсан өөрийн тань нутаг

5a Алма 48:1.

6a су Шударга ёс.

7a Алма 47:18, 22–24.

су Аллага.

б су Там.

11a Иохан 8:42–44.

12a 2 Ниф. 5:5–8.

хүртэл дагах болно; тийм ээ, мөн энэ нь цусыг цусаар, тийм ээ, амийг амиар байх болно; мөн би та нарыг газрын гадаргуугаас үгүй болтол устгагдах хүртэл чинь та нартай тулалдах хийх болно.

13 Болгоогтун, би бас миний хүмүүс ч түүнчлэн ууртай байна.; та нар биднийг хөнөөхийг эрэлхийлсэн, харин бид зөвхөн өөрсдийгөө өмгөөлөхийг эрэлхийлж байлаа. Гэвч болгоогтун, хэрэв та нар цаашид биднийг устгахыг эрэлхийлэх аваас бид ч та нарыг устгахыг эрэлхийлэх болно; тийм ээ, мөн бид эх нутгаа, анхныхаа өв болох нутгийг эрэлхийлэх болно.

14 Эдүгээ би захидлаа цэглэе. Би бол Моронай; би бол Нифайн хүмүүсийн удирдагч.

15 Эдүгээ улиран тохиох дор Амморон, энэ захидлыг хүлээн аваад, ууртай байв; мөн тэрээр өөр нэг захидлыг Моронайд бичив, мөн түүний бичсэн үгс нь эдгээр бөлгөө, өгүүлсэн нь:

16 Би бол Амморон, леменчүүдийн хаан; би бол та нарын “алсан Амаликаагийн дүү нь. Болгоогтун, түүний цусны өшөөг би та нарт тохоох болно, тийм ээ, мөн би их цэрэгтэйгээ та нарын дээр очих болно, учир нь та нарын сүрдүүлгээс би айх нь үгүй.

17 Учир нь болгоогтун, та нарын эцэг өвгөд ах нартаа бурууг үйлдэн, үүнийхээ хэрээр тэдэнд өөрсдөд нь “зүй

ёсоор хамаарах засаглах эрхийг тэд тэднээс дээрэмдэн авсан билээ.

18 Мөн эдүгээ болгоогтун, хэрэв та нар зэвсгээ хаяж, мөн өөрсдийгөө засаг төр нь зүй ёсоор хамаарагдах тэдэнд захирагдахаар харьяалуулбал, тэгвэл би өөрийн хүмүүсийг зэр зэвсгээ буулгаж мөн цаашид дайтахгүй байхаар болгоно.

19 Болгоогтун, та миний болон миний хүмүүсийн эсрэг олон сүрдүүлгийг илэрхийлжээ; гэвч болгоогтун, бид таны сүрдүүлгээс айхгүй.

20 Гэсэн хэдий ч би дайны эрсдээ зориулан хүнс нөөцөлж болохын тулд би таны саналын дагуу хоригдлуудыг солилцохыг дуртайяа зөвшөөрч байна; мөн нифайчуудыг эрх мэдэлдээ харьяалуулна эс бөгөөс тэдний мөнхийн мөхлийг хүртэл, мөнхийн байх дайныг бид хийх болно.

21 Мөн бид эсэргүүцсэн хэмээн таны хэлэх тэр Бурханы талаар бол болгоогтун, бид тийм нэгэнийг мэдэх нь үгүй; та нар ч бас мэдэх нь үгүй; гэвч хэрэв ийм нэгэн байдаг аваас, тэрээр та нарын нэгэн адил биднийг бүтээсэн байж магад хэмээн бид бодно.

22 Мөн хэрэв чөтгөр болоод там гэж байдаг аваас, болгоогтун тэрээр тийм газар одсон хэмээн таны цухуйлгасан, таны хөнөөсөн тэр ахтай минь хамт байлгахаар тэрээр таныг тийш илгээхгүй гэж үү?

Гэвч болгоогтун эдгээр зүйл хамаагүй.

23 Би бол Амморон, мөн танай эцэг өвгөдийн хүчилж мөн Иерусалимаас гаргаж авчирсан “Зорамын удмын нэгэн билээ.

24 Мөнхүү болгоогтун эдүгээ, би бол лемен үндэстний сөс ихтэй нэгэн; болгоогтун, энэ дайн тэдний буруу зүйлүүдийн өшөөг авахаар дэгдээгдсэн буюу, мөн тэдний засаглах эрхүүдийг хадгалах мөн олж авахын төлөө бөлгөө; мөн би Моронайд илгээх захидлаа дуусгая.

БҮЛЭГ 55

Моронай хоригдлуудыг солилцохоос татгалзав—Лемен үндэстний харуулууд заль мэхэнд автагдан согтов, мөн Нифайн хоригдлууд чөлөөлөгдөв—Гидийн хот цус урсгалгүйгээр буцаан авгадав. Ойролцоогоор мээ 63–62 он.

Эдүгээ улиран тохиох дор Моронай энэ захидлыг хүлээн аваад тэрээр илүү ихээр уурлав, учир нь Амморон “заль луйврынхаа тухай төгс мэдлэгтэйг тэр мэдэж байв; тийм ээ, Нифайн хүмүүсийн эсрэг түүнийг дайн хийхээр болгосон нь шударга шалтгаан биш гэдгийг Амморон өөрөө мэдэж буйг тэрээр мэдэж байлаа.

2 Мөн тэрээр хэлэв: Болгоогтун, миний захидалдаа дурдсаны адилаар, тэр зо-

рилгоосоо няцахгүй бол би Амморонтой хоригдлуудыг солилцохгүй; учир нь би тэрээр байгаагаасаа илүү хүч чадалтай болохыг би түүнд зөвшөөрөхгүй.

3 Болгоогтун, леменчүүдийн хоригдлууд болгон авсан манай хүмүүсийг харгалзаж байгаа газрыг нь би мэднэ; мөн Амморон миний захидалдаа хүссэнийг зөвшөөрөөгүйн учир, болгоогтун, өөрийнхөө үгсийн дагуу би түүнд үйлдэх болно; тийм ээ, тэд энх амгаланг гуйх хүртэл нь би тэдний дунд үхлийг эрэлхийлэх болно.

4 Мөн эдүгээ улиран тохиох дор Моронай эдгээр үгсийг хэлээд, тэрээр тэдний дундаас Леменийн удмынх болох нэг хүнийг олж болохын тулд тэрээр өөрийн хүмүүсийн дунд эрэл хийгдэх болгов.

5 Мөнхүү улиран тохиох дор нэр нь Лемен асан нэгнийг тэд олов; мөн тэрээр Амаликайгаар алагдсан хааны зарц нарын “нэг байжээ.

6 Эдүгээ Моронай нифайчуудыг харгалзаж байсан харуулууд дээр Леменийг мөн өөрийн хүмүүсээс цөөн хэдийг нь очих болгов.

7 Эдүгээ нифайчууд Гид хотод харгалзагдаж байв; тиймийн тул Моронай Леменийг томилж мөн цөөн тооны эрсийг түүнтэй явахаар болгов.

8 Мөн үдэш болоход Лемен нифайчуудыг харгалзаж байсан харуулууд дээр очиж, мөн

болгоогтун, тэд түүний ирж явахыг хараад мөн тэд түүний зүг хашгирав; гэвч тэрээр тэдэнд хэлэв: Бүү ай; болгоогтун, би бол леменийх. Болгоогтун, бид нифайчуудаас оргон ирлээ, мөн тэд унтаж байна; мөн болгоогтун бид тэдний дарснаас авч мөн өөрсөдтэйгээ авчирлаа.

9 Эдүгээ леменчүүд эдгээр үгийг сонсоод тэд түүнийг баяртайгаар хүлээн авав; мөн тэд түүнд хэлэв: Бид ууж болохын тулд дарснаасаа бидэнд өг; та нар ийн өөрсөдтэйгөө дарс авчирсанд чинь бид баяртай байна, учир нь бид ядарчээ.

10 Гэвч Лемен тэдэнд хэлэв: Нифайчуудын эсрэг бид тулалдахаар явах хүртлээ дарсаа хадгалцгаая. Гэвч энэ үгс нь дарснаас уух тэдний хүслийг нь л нэмэгдүүлэв;

11 Учир нь, тэд хэлэв: Бид ядарсан, тиймийн тул бидэнд дарснаас хүртэхийг зөвшөөр, мөн нифайчуудын эсрэг явахад биднийг хүчирхэгжүүлэх дарсны хувиа бид удахгүй авах болно.

12 Мөн Лемен тэдэнд хэлэв: Та нар хүслийнхээ дагуу хийж болно.

13 Мөнхүү улиран тохиох дор тэд дарснаас ихээр хүртэв; мөн тэдэнд амт нь таалагдаж, тиймийн тул тэд үүнээс илүү ихээр хүртэв; мөн энэ нь, үүнийг хүчтэйгээр бэлтгэсэн байсны учир хүчтэй байв.

14 Мөнхүү улиран тохиох

дор тэд ууж мөн наргиж, мөн тэд бүгд согтоцгоов.

15 Мөн эдүгээ Лемен болон түүний хүмүүс тэд бүгд согтоцгоосныг бас гүн нойронд автсаныг хараад, тэд Моронайд эргэж ирээд мөн тохиолдсон бүх зүйлийг түүнд хэлэв.

16 Мөн эдүгээ энэ нь Моронайн төлөвлөгөөний дагуу байв. Мөн Моронай эрчүүдээ дайны зэр зэвсгээр бэлтгэсэн байв; мөн тэрээр леменчүүдийг гүн нойрондоо бас согтуу байхад нь Гид хотод очиж, мөн хоригдлуудад дайны зэвсгийг шидэж өгчээ, үүний улмаас тэд бүгд зэвсэглэгдэв;

17 Тийм ээ, Моронайг тэдгээр бүх хоригдлуудыг зэвсэглэхээ, бүр дайны зэвсэг хэрэглэж чадаж байсан тэдгээр бүх хүүхдүүдийг нь мөн эмэгтэйчүүдийг нь хүртэл буюу; мөн тэдгээр бүх зүйл бүрэн нам гүм байдалд хийгдэв.

18 Гэвч хэрэв тэд леменчүүдийг сэрээсэн бол, болгоогтун тэд согтуу байлаа мөн нифайчууд тэднийг хөнөөж чадах байв.

19 Гэвч болгоогтун, энэ нь Моронайн хүсэл бус байв; аллагад өөрөөр хэлбэл “цус урсгахад тэр баясдаггүй байв, харин тэрээр өөрийн хүмүүсийг устгалаас аврахдаа баясдаг байв; мөн тэрээр шударга бусаар үйлдэхгүй байж болох энэхүү шалтгааны улмаас, тэрээр леменчүүдийн дээр бууж мөн тэднийг согтуу байхад нь устгасангүй ажээ.

20 Гэвч тэрээр хүслүүдээ гүйцээв; учир нь хотын хэрмэн дотор байсан Нифай үндэсний тэдгээр хоригдлуудыг зэвсэглэж, мөн хэрмэн дотор байсан хэсгүүдийг эзэмшилдээ авах хүчийг тэдэнд өгсөн байв.

21 Мөн тэгээд тэр өөртэйгөө хамт байсан эрчүүдийг тэднээс хэсэг холдуулаад, мөн леменчүүдийн их цэргийг бүслэхээр болгов.

22 Эдүгээ болгоогтун энэ нь шөнийн цагаар хийгдэж, иймээс леменчүүд өглөө сэрээд тэд гадуураа нифайчуудаар бүслэгдэж, мөн дотор талд хоригдлууд зэвсэглэгдсэнийг үзэв.

23 Мөн тэд нифайчууд тэдний дээр хүчтэйг ийн харав; мөн ийм нөхцөл байдалд тэд нифайчуудтай тулалдах нь зохимжтой бусыг олж мэдэв; тиймийн тул тэдний ерөнхий ахмад нь дайны зэвсгүүдийг нь шаардаж, мөн тэд тэдгээрийг авчирч, мөн нигүүлслийг гуйн, нифайчуудын хөлд тэдгээрийг хаяв.

24 Эдүгээ болгоогтун, энэ нь Моронайн хүсэл байв. Тэрээр тэднийг дайны олзлогдогсод болгон авч, мөн хотыг эзэмшилдээ аваад, мөн нифайчууд асан, бүх хоригдлуудыг чөлөөлөгдөх болгов; мөн тэд Моронайн их цэрэгт элсэж, мөн түүний их цэрэгт агуу хүч сэлбэв.

25 Мөнхүү улиран тохиох дор өөрийн хоригдлууд болгож

баривчилсан леменчүүдийг тэрээр Гид хотыг хүрээлэх бэхлэлтүүдийг хүчирхэгжүүлэхийн тулд “хөдөлмөрлөж эхлэх болгов.

26 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Гид хотыг өөрийн хүслүүдийн дагуу бэхлээд, тэрээр хоригдлуудыг Өгөөмөр хотод аваачигдах болгов; мөн тэрээр түүнчлэн тэр хотыг үлэмж их хүчээр хамгаалж байжээ.

27 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн бүх хуйвалдаан байсаар байсан хэдий ч, тэд баривчилсан бүх хоригдлуудаа харгалзан мөн хамгаалж, мөн түүнчлэн тэд дахин олж авсан бүх нутаг дэвсгэрээ мөн давамгай байдлаа хадгалсан ажгуу.

28 Мөнхүү улиран тохиох дор нифайчууд дахин ялалт байгуулж, мөн эрхүүдээ мөн онцгой боломжуудаа буцаан олж эхлэв.

29 Олон удаа леменчүүд тэднийг шөнөөр бүслэхийг завдсан хэдий ч, эдгээр оролдлогууддаа тэд олон хүнээ хоригдол болгон алдсан ажээ.

30 Мөн тэднийг хороор эсвээс согтуу байхад нь устгаж болохын тулд дарснаасаа нифайчуудад өгөхийг тэд олон удаа оролджээ.

31 Гэвч болгоогтун, нифайчууд өөрсдийн энэ зүдгүүрийн үед Их Эзэн Бурханаа “санахдаа хойрго байсангүй. Тэднийг занганд оруулах нь тэдэнд боломжгүй байв; тийм

ээ, тэд эхлээд Леменийн зарим хоригдлуудад амсуулахаас бусдаар, дарснаас нь хүртэхгүй байв.

32 Мөн тэдний дунд ямар ч хор өгөгдөхөөргүй тийм хянамгай байв; учир нь хэрэв тэдний дарс лемен үндэстнийг хордуулбал, энэ нь түүнчлэн нифай үндэстнийг ч хордуулах болой; мөн тэд бүх архинуудыг нь тийн шалгасан бөлгөө.

33 Мөн эдүгээ улиран тохиох дор Моронайн хувьд Мориантан хотыг дайрах бэлтгэл хийх нь зайлшгүй шаардлагатай байв; учир нь болгоогтун, леменчүүд, өөрсдийн хөдөлмөрөөр, Мориантан хотыг үлэмж бат бэх хориглолт болтол нь бэхэлсэн байв.

34 Мөн тэд уг хотод нэмэгдэл хүчийг, мөн түүнчлэн хүнсний нөөц хангамжуудыг авчирсаар байв.

35 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин ес дэх он төгсөв.

БҮЛЭГ 56

Леменчүүдтэй хийж буй дайны байдлын тухай захидлыг Хиламан Моронайд илгээв— Антипус, Хиламан нар леменчүүдийн дээр агуу ялалт байгуулав— Хиламаны хоёр мянган залуу хөвгүүд гайхамшигтай хүчээр тулалдаж, тэдний хэн нь ч алагдсангүй. 1 дүгээр хэсэг ойролцоогоор мэв 62 он; 2–19 дүгээр хэсэг ойролцоогоор мэв 66 он;

мөн 20–57 дугаар хэсэг ойролцоогоор мэв 65–64 он.

Мөнхүү эдүгээ улиран тохиох дор шүүгчдийн засаглалын гуч дахь оны эхэнд, эхний сарын хоёр дахь өдөр, Моронай уг нутгийн тэрхүү хэсэг дэх хүмүүсийн хэрэг явдлыг тэмдэглэсэн захидлыг Хиламанаас хүлээн авлаа.

2 Мөн түүний бичсэн үгс нь эдгээр бөлгөө, өгүүлсэн нь: Их Эзэний хувьд түүнчлэн дайн тулаан дахь зовлон бэрхшээлүүдийн хувьд ч эрхэм хайрт ах Моронай минь; болгоогтун, хайрт ах минь, уг нутгийн энэ хэсэг дэх бидний дайны талаар танд хэлэх зарим зүйл надад байна.

3 Болгоогтун, Нифайн нутгаас доош Аммоны авчирсан хүмүүсийн “хоёр мянган хөвгүүд— эдүгээ тэд бол бидний өвөг Лихайн ууган хүү асан лемений удам байсныг та мэдэж байгаа;

4 Эдүгээ тэдний уламжлалуудын эсвэл тэдний итгэлгүйн талаар танд давтах нь надад хэрэггүй, учир нь та эдгээр бүх зүйлийн талаар мэднэ—

5 Тиймийн тул эдгээр залуу эрсийн хоёр мянга нь дайны зэвсгүүдээ агсаж, мөн намайг удирдагчаа болоосой хэмээснийг би танд хэлэх нь хангалттай; мөн бид улс орноо хамгаалахаар урагшлан ирсэн билээ.

6 Мөн эдүгээ тэдний эцгүүд тэд ах дүүсийнхээ эсрэг цус

урсгахаар дайны зэр зэвсгээ агсахгүй хэмээн хийсэн “гэрээний талаар та түүнчлэн мэднэ.

7 Гэвч хорин зургадугаар онд, тэд өөрсдийнх нь төлөө гэх бидний зүдгүүрүүд хийгээд бидний бэрхшээлүүдийг хараад, тэд хийсэн гэрээгээ “цуцалж мөн биднийг хамгаалахын тулд дайны зэвсгүүдээ агсах гэж байв.

8 Гэвч тэд хийсэн гэрээгээ цуцлахыг би тэдэнд зөвшөөрөхгүй байв, Бурхан биднийг хүчирхэгжүүлэх буйза, иймээс тэд тавьсан тангаргаа биелүүлэхийн учир бид илүү ихээр зовохгүй байх болно хэмээн би бодсоноос буюу.

9 Гэвч болгоогтун, бид агуу баяртай байж болох нэгэн зүйл энэ байна. Учир нь болгоогтун, хорин зургадугаар онд, би, Хиламан, эдгээр хоёр мянган залуу эрсийн тэргүүнд Иуда хотод, уг нутгийн тэр хэсгийн хүмүүсийн дээр таны удирдагчаар нь тохоосон Антипус туслахаар жагсан одсон билээ.

10 Мөн хүчинд нь Антипус үлэмж баясан тэр хоёр мянган хөвгүүдийг, (учир нь тэд хөвгүүд гэж нэрлэгдэхээр зохистой билээ) Антипусын их цэрэгт нэгтгэв; учир нь болгоогтун, леменчүүдээр түүний их цэрэг багасгагдсан байж, учир нь тэдний цэргүүд бидний эрчүүдээс тоолшгүй олныг нь алсан

юм, үүний улмаас бидэнд гашуудах шалтгаан буй.

11 Гэсэн хэдий ч, бид энэ зүйлийн хувьд сэтгэлээ тайтгаруулж болох нь, тэд улс орон мөн Бурханыхаа хөдөлгөөний төлөө амь эрсэдсэн юм, тийм ээ, мөн тэд “баяртай байгаа.

12 Мөн түүнчлэн леменчүүд олон хоригдлыг, бүгд ерөнхий ахмадууд болох тэднийг авч үлдсэн байв, учир нь өөр хэний ч амийг тэд хэлтрүүлсэнгүй. Мөн эдүгээ тэд энэ үед Нифайн нутагт байгаа хэмээн бид бодно; хэрэв тэд алагдаагүй бол энэ нь ийм буйза.

13 Мөн эдүгээ маш олон баатарлаг эрсийн маань цусыг урсгаснаар леменчүүдийн эзэмшилдээ авсан хотууд нь эдгээр болой:

14 Мантай нутаг, өөрөөр хэлбэл Мантай хот, мөн Зиезром хот, мөн Кууманай хот, мөн Антипара хот юм.

15 Мөн эдгээр нь намайг Иуда хотод хүрч ирэхэд тэдний эзэмшиж байсан тэр хотууд юм; мөн уг хотыг бэхлэн хамгаалахаар чадлаараа хөдөлмөрлөж байхад нь би Антипус болон түүний хүмүүсийг олов.

16 Тийм ээ, мөн тэд сэтгэлээрээ, үүний нэгэн адил биеэрээ ч сульдсан байв; учир нь тэд өдөр нь баатарлагаар тулалдаж, шөнө нь хотуудаа хадгалан хамгаалахаар хөдөлмөрлөж байв; мөн тийн тэд

төрөл бүрийн агуу зовлонгуудыг тэвчсэн ажээ.

17 Мөн эдүгээ тэд энэ газарт ялах эс бөгөөс үхэхээр хатуу шийдсэн байв; тиймийн тул миний өөртэйгөө авчирсан тэр багахан хүч, тийм ээ, миний тэдгээр хөвгүүд, тэдэнд агуу найдлага хийгээд их баясал өгсөн хэмээн та ойлговол болно.

18 Мөн эдүгээ улиран тохиох дор Антипус их цэрэгтээ нэмэгдэл хүч хүлээн авсныг леменчүүд хараад, тэд Иуда хотын эсрэг, өөрөөр хэлбэл бидний эсрэг тулалдахаар ирэхгүй байхыг Аммороны тушаалаар албадуулагдав.

19 Мөн бид Их Эзэний ээл хишгийг хүртэв; учир нь тэд энэ сул дорой байдалд маань бидний дээр ирсэн бол багахан цэргийг маань устгах байсан байж магад; гэвч бид тийн хамгаалагдав.

20 Тэд авсан тэр хотуудаа хадгалан хамгаалахыг Аммоноор зарлиг болгогдов. Мөн хорин зургадугаар он ийн төгсөв. Мөн хорин долдугаар оны эхэнд бид хотоо мөн өөрсдийгөө батлан хамгаалахад бэлтгэсэн байв.

21 Эдүгээ бид леменчүүдийг бидний дээр ирээсэй хэмээх хүсэлтэй байв; учир нь бид тэдний хориглолтонд тэднийг довтлох хүсэлгүй байв.

22 Мөнхүү улиран тохиох дор тэд шөнөөр бас өдрөөр умард дахь манай бусад хотуудад дайралт хийхээр биднийг өнгөрөхгүй байхын тулд бид эргэн тойрондоо,

леменчүүдийн хөдөлгөөнүүдийг ажиглуулахаар тандуулуудыг байлгаж байв.

23 Учир нь тэд тэр хотууддаа тэдэнтэй тулгарахад хангалттай хүчтэй байгаагүйг бид мэдэж байв; тиймийн тул хэрэв тэд бидний дэргэдүүр өнгөрвөл, бид тэдний араас нь, мөн тийн тэд урдаасаа тулгарахад нь бас нэгэн зэрэг араас нь довтлох буюу дайрах хүсэлтэй байв. Бид тэднийг дийлж чадна хэмээн бодож байв; гэвч болгоогтун, бидний энэ хүсэл бүтсэнгүй.

24 Тэд бүх их цэрэгтэйгээ ч бидний дэргэдүүр өнгөрч зүрхэлсэнгүй бас хэсгээрээ ч зүрхэлсэнгүй, тэд хангалттай хүчтэй байгаагүй болохоор тэд унах вий хэмээсэн бөлгөө.

25 Тэд бас Зарахемла хотын эсрэг жагсан очиж ч зүрхэлсэнгүй; бас тэд Нифайха хотын зүг, Сидон голын эхийг гаталж ч зүрхэлсэнгүй.

26 Мөн тийн, тэд хүчээрээ, өөрсдийн авсан хотуудыг хадгалан хамгаалахаар хатуу шийдсэн байв.

27 Мөн эдүгээ улиран тохиох дор энэ оны хоёр дахь сард, тэдгээр хоёр мянган хөвгүүдийн минь эцгүүдээс хүнсний нөөц бидэнд авчрагдав.

28 Мөн түүнчлэн Зарахемла нутгаас хоёр мянган эрс бидэнд илгээгдэв. Мөн тийн бид арван мянган эрсээр мөн тэдэнд, мөн түүнчлэн тэдний эхнэр мөн хүүхдэд нь зориулагдсан хүнсээр бид бэлтгэгдэв.

29 Мөн леменчүүд, бидний

хүч өдөр бүр нэмэгдсээр, мөн биднийг дэмжих хүнс ирсээр буйг тийн харснаас, тэд айж эхлэв, мөн хэрэв боломжтойсон бол бидний хангамжууд мөн хүчийг хүлээн авахыг төгсгөл болгохоор дайрч эхлэв.

30 Эдүгээ бид леменчүүд үүндээ тэвдэж эхэлж буйг үзээд, бид тэдний дээр нэгэн зальт арга хэрэгжүүлэхийг хүсч байв; тиймийн тул Антипус намайг залуу хөвгүүдтэйгээ зэргэлдээх нэгэн хот уруу хүнс зөөж байгаа мэтээр, зэргэлдээх хотын зүг жагсан одохыг тушаав.

31 Мөн бид Антипара хотын дэргэдүүр, тэнгисийн эргээр хиллэдэг цаадах хотынх нь зүг явах гэж байгаа мэтээр, жагсан алхах ёстой байв.

32 Мөнхүү улиран тохиох дор бид хүнстэйгээ байгаа мэтээр, уг хот уруу жагсан алхав.

33 Мөнхүү улиран тохиох дор үлдэгдлийг нь уг хотыг хамгаалуулахын тулд орхиод Антипус их цэргийнхээ нэг хэсэгтэй жагсан одов. Гэвч намайг багахан цэрэгтэйгээ явж мөн Антипара хотын дэргэд ирэх хүртэл тэрээр жагсан гарч ирсэнгүй.

34 Мөн эдүгээ, Антипара хотод Леменчүүдийн хамгийн хүчирхэг цэрэг; тийм ээ, хамгийн олон тоотой нь байрласан байв.

35 Мөнхүү улиран тохиох дор тэд тандуулуудаараа мэдээлэгдсэний дараа, тэд их цэрэгтэйгээ урагшилж мөн бидний эсрэг жагсан ирэв.

36 Мөнхүү улиран тохиох дор бид тэдний өмнө нь, умардад зугтав. Мөн бид леменчүүдийн хамгийн хүчирхэг цэргийг тийн холдуулан удирдсан болой;

37 Тийм ээ, бүр нилээд их зайд, тэгсний хэрээр тэд Антипусын их цэрэг тэднийг чадлаараа мөрдөж байгааг хараад, тэд баруун тийшээ ч мөн зүүн тийшээ ч эргэсэнгүй, харин бидний араас шулуухан давшихаа үргэлжлүүлэв; мөн, бидний бодсоноор, Антипус тэднийг гүйцэхээс урьд биднийг хөнөөх нь, мөн энэ нь тэд манай хүмүүсээр бүслэгдэхгүйн тулд тэдний зорилго байв.

38 Мөн эдүгээ Антипус, бидэнд тулгарсан аюулыг болгоож, их цэргийнхээ алхааг түргэсгэв. Гэвч болгоогтун, энэ нь шөнө байв; тиймийн тул тэд биднийг гүйцсэнгүй, бас Антипус ч тэднийг гүйцсэнгүй; тиймийн тул бид хоноглохоор буудаллав.

39 Мөнхүү улиран тохиох дор үүр цайхаас өмнө, болгоогтун, леменчүүд биднийг мөрдөж байв. Эдүгээ бид тэдэнтэй тэмцэлдэхэд хангалттай хүчирхэг байсангүй; тийм ээ, залуу хөвгүүд маань тэдний гарт орохыг би хүлцэхгүй байв; тиймийн тул бид жагсан явахаа үргэлжлүүлж, мөн бид аглаг буйд тийш жагсан одов.

40 Эдүгээ тэд бүслэгдэх болуузай хэмээснээс тэд баруун тийшээ ч бас зүүн тийшээ ч эргэж зүрхэлсэнгүй; тэд

намайг гүйцэж мөн бид тэдний эсрэг зогсож чадахгүй, харин алагдаж, мөн тэд оргох вий хэмээнээс би ч бас баруун тийш ч, бас зүүн тийш ч эргэхгүй байв; мөн бид тийн бүхэл өдрийн турш бүр харанхуй болтол аглаг буйд тийш зугтав.

41 Мөнхүү улиран тохиох дор дахин, өглөөний гэгээ ороход леменчүүд бидний дээр ирж буйг бид хараад, мөн бид тэдний өмнө зугтав.

42 Гэвч улиран тохиох дор тэд биднийг хол биш мөрдөөд зогсов; мөн энэ нь долдугаар сарын гурав дахь өдрийн өглөө байв.

43 Мөн эдүгээ, тэд Антипу-саар гүйцэгдсэн эсэхийг бид мэдсэнгүй, гэвч би хүмүүстээ хэлэв: Болгоогтун, тэд биднийг урхиндаа оруулж болохын тулд, биднийг өөрсдийнхөө эсрэг ирүүлэх зорилгоор азнан зогссон эсэхийг бид мэдэхгүй;

44 Тиймийн тул та нар юу хэлнэ, хөвгүүд минь, та нар тэдний эсрэг тулалдахаар явах уу?

45 Мөн эдүгээ би танд хэлье, хайрт ах Моронай минь, би хэзээ ч тийм агуу “зоригийг үзээгүй, үгүй, бүх нифайчуудын дунд ч үгүй билээ.

46 Өөрөөр хэлбэл би тэднийг хөвгүүд минь хэмээн үргэлж дуудах болсон шиг (учир нь тэд бүгд маш залуу байв) тэрчлэн тэд надад хэлэв: Эцэг минь, Бурхан минь бид

хамт гэдгийг болгоогтун, мөн тэрээр бидний унахыг хүлцэхгүй; тэгвэл биднийг урагш давшихыг зөвшөөрөөч; хэрэв тэд биднийг зүгээр орхивол бид ах дүүсээ хөнөөхгүй; тиймийн тул, тэд Антипусын их цэргийг давамгайлах болуузай хэмээн явахыг маань зөвшөөрөөч.

47 Эдүгээ тэд хэзээ ч тулалдаж байсангүй, гэсэн хэдий ч тэд үхлээс айсангүй; мөн тэд аминаасаа илүүтэйгээр эцгүүдийнхээ “эрх чөлөөг бодож байв; тийм ээ, хэрэв тэд эргэлзэхгүй аваас, Бурхан тэднийг чөлөөлнө гэдэгт тэд “эхчүүдээрээ сургагдсан байлаа.

48 Мөн тэд эхчүүдийнхээ үгсийг надад давтаж, хэлсэн нь: Эхчүүд маань үүнийг мэдэж байсан гэдэгт бид эргэлзэхгүй байна.

49 Мөнхүү улиран тохиох дор биднийг мөрдөж асан леменчүүдийн эсрэг өөрийн хоёр мянгатай хамт би эргэж очлоо. Мөн эдүгээ болгоогтун, Антипусын их цэрэг тэднийг гүйцсэн байв, мөн аймшигт тулаан эхлэх нь тэр.

50 Ийм богино хугацаанд урт замыг туулсан учир, Антипусын их цэрэг ядарснаас, леменчүүдийн гарт орох магадгүй байв; мөн хэрэв би өөрийн хоёр мянгатайгаа эргэж ирээгүй бол леменчүүд зорилгодоо хүрч болохоор байв.

51 Учир нь, Антипус мөн түүний удирдагчдаас олон

нь, илдэнд өртөж унасан байв, жагсан алхсан хурдаасаа болсон ядралынхаа улмаас буюу — тиймийн тул Антипусын хүмүүс, удирдагчдынхаа уналтын учир самгардсанаас, леменчүүдийн өмнө ухарч эхлэв.

52 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд зоригжин, мөн тэднийг мөрдөж эхлэв; мөн леменчүүд тийн тэднийг эрч хүчтэйгээр мөрдөж байхад Хиламан тэдний араас нь өөрийн хоёр мянгатайгаа ирж, мөн тэднийг үлэмж ихээр хөнөөж эхлэв, үүний хэрээр леменчүүдийн бүх их цэрэг зогсож мөн Хиламаны зүг эргэв.

53 Эдүгээ леменчүүд цааш хандан эргэснийг Антипусын хүмүүс хараад, тэд эрчүүдээ нэгтгэн цуглуулж мөн леменчүүдийн ар талаас дахин ирэв.

54 Мөн эдүгээ улиран тохиох дор бид, Нифайн хүмүүс, Антипусын хүмүүс, мөн би хоёр мянгатайгаа, леменчүүдийг бүсэлж, мөн тэднийг хөнөөв; тийм ээ, үүний хэрээр тэд дайны зэвсгүүдээ мөн түүнчлэн өөрсдийгөө дайны олзлогдогсод болгон өгөхөөр албадуулагдав.

55 Мөн эдүгээ улиран тохиох дор тэд өөрсдийгөө бидэнд тушаан өгснийх нь дараа, болгоогтун, би надтай хамт тулалдсан тэдгээр залуу эрчүүдээ, тэднээс олон нь алагдсан байх хэмээн айснаас тоолов.

56 Гэвч болгоогтун, их баяс-

лыг минь төрүүлэн, тэднээс “нэг ч бодгаль газарт унаагүй байв; тийм ээ, мөн тэд Бурханы хүчтэй хамт мэт тулалдсан байв; тийм ээ, хүмүүн тийм гайхамшигтай хүчээр тулалдаж байсан нь хэзээ ч үзэгдэж байсангүй; мөн тэд тэднийг айлгаж ийм агуу хүчтэйгээр тэд леменчүүдийн дээр буусан бөлгөө; мөн энэ шалтгааны учир леменчүүд өөрсдийгөө дайны олзлогдогсод болгон өгсөн болой.

57 Мөн бид тэднийг леменчүүдийн их цэргээс зайдуу байлгахаар харгалзаж болохоор, олзлогдогсод зориулсан байр бидэнд байгаагүй учир, тиймийн тул бид тэднийг, Антипусын алагдаагүй үлдсэн эрчүүдийн нэгэн хэсэгтэй хамт Зарахемла нутаг уруу илгээв; мөн үлдэгдлийг нь би авч мөн залуу “аммончуудтайгаа тэднийг нэгтгээд, мөн Иуда хотын зүг буцаж жагсан одов.

БҮЛЭГ 57

Антипараг авснаа мөн Кууманай дахь бууж өгөлтийг нь, түүнчлэн хожим нь уг хотыг батлан хамгаалснаа Хиламан өгүүлэв — Түүний аммон үндэстэн залуучууд эрэлхэгээр тулалдаж; бүгд шархдан, харин нэг нь ч алагдсангүй — Лемен үндэстэн хоригдлууд алагдсаныг мөн оргосныг Гид илтгэв. Ойролцоогоор мээ 63 он.

Мөн эдүгээ улиран тохиох

дор хаан Амморноос, хэрэв би манайхны барьсан дайны олзлогдогсдоо өгөх юм бол тэрээр Антипара хотыг бидэнд өгнө хэмээн дурдсан захидлыг би хүлээн авлаа.

2 Гэвч би хаанд, бидний цэргийн хүч Антипара хотыг хүчээрээ авахад хангалттайг бид лавтай мэднэ; мөн тэр хотын төлөө олзлогдогсдоо өгснөөрөө бид өөрсдийгөө ухаалаг бус хэмээн бодно, мөн бид олзлогдогсдоо зөвхөн олзлогдогсдоор солилцох болно гэсэн захидлыг илгээв.

3 Мөн Амморон миний хүсэлтээс татгалзав, учир нь тэр олзлогдогсдыг солилцсонгүй; тиймийн тул бид Антипара хотын эсрэг явахаар бэлтгэлүүдийг хийж эхлэв.

4 Гэвч Антипарагийн хүмүүс уг хотыг орхин, мөн өөрсдийн эзэмшиж асан бусад хотуудын зүг тэдгээрийг бэхлэхээр зугтав; мөн Антипара хот тийн бидний гарт оров.

5 Мөн шүүгчдийн засаглалын хорин найм дахь он тийн төгсөв.

6 Мөнхүү улиран тохиох дор хорин есдүгээр оны эхэнд, бид хүнсний хангамжуудыг, мөн түүнчлэн их цэрэгтээ нэмэлт хүч болгон миний хоёр мянгын жижиг бүлэгт ах дүүстэйгээ нэгдэхээр ирсэн аммончуудын жаран “хөвгүүнийг, үүнээс гадна Зарахемла нутгаас, мөн эргэн тойрны нутгаас зургаан мянган тооны эрчүүдийг хүлээн авав.

Мөн эдүгээ болгоогтун, бид хүчтэй байв, тийм ээ, мөн түүнчлэн бидэнд элбэг их хүнсний хангамжууд авчрагдсан байв.

7 Мөнхүү улиран тохиох дор Кууманай хотыг хамгаалахаар байрлуулагдсан их цэрэгтэй тулалдах нь бидний хүсэл байв.

8 Мөн эдүгээ болгоогтун, бид удалгүй хүслээ биелүүлснийг танд би үзүүлэх болно; тийм ээ, хүчит цэргээрээ, өөрөөр хэлбэл хүчит цэргүүдийнхээ нэг хэсгээр, бид шөнөөр, Кууманай хотыг, тэд хүнсний хангамжаа хүлээн авахаас нь өмнөхөн тэднийг бүслэв.

9 Мөнхүү улиран тохиох дор бид олон шөнийн турш уг хотыг бүслэн буудаллав; гэвч бид илдээ дэрлэн унтаж, мөн, леменчүүд бидний дээр шөнөөр ирж мөн биднийг хөнөөж чадахгүйн тулд харуулуудыг гаргаж байв, үүнийгээ тэд олон удаа оролдов; гэвч тэд үүнийг оролдох болгондоо тэдний цус асгарсан билээ.

10 Хэсэг хугацааны дараа хүнсний хангамжууд нь хүрч ирэв, мөн тэд шөнөөр хотод орох гэж байв. Мөн леменчүүдийн оронд, бид нифайчуудыг угтав; тиймийн тул, бид тэднийг мөн тэдний хүнсний хангамжуудыг нь авав.

11 Мөн леменчүүд энэ маягаар дэмжлэгээсээ таслагдсан хэдий ч, тэд хотыг хадгалан хамгаалахаар хатуу шийдсэн

хэвээр байв; тиймийн тул бид тэдгээр хүнсний хангамжуудыг авч мөн тэдгээрийг Иуда уруу, мөн Зарахемлагийн нутаг дахь олзлогдогсодоо илгээх нь зайлшгүй болов.

12 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд тусламж авах бүх найдлагаа алдаж эхэлтэл тийм ч олон өдөр өнгөрсөнгүй; тиймийн тул тэд хотыг бидний гарт оруулав; мөн бид Кууманай хотыг олж авах төлөвлөгөөгөө тийн биелүүлсэн болой.

13 Гэвч улиран тохиох дор олзлогдогсод маань тийм олон тоотой байснаас, бидний тоо их олон хэдий ч, бид бүх цэргүүдээ ажиллуулж байж тэднийг харгалзуулах, эс бөгөөс тэднийг үхэлд хүргэх ёстой болов.

14 Учир нь болгоогтун, тэд олон тоогоороо босож, мөн чулуугаар, мөн бороохойгоор, өөрөөр хэлбэл тэд гарт нь тааралдсан болгоноор тулалдаж, үүний хэрээр тэд өөрсдийгөө дайны олзлогдогсод болгон өгсний дараа бид тэднээс хоёр мянга гаруйг нь хөнөөсөн бөлгөө.

15 Тиймийн тул бид амийг нь төгсгөж, эс бөгөөс гартаа илдтэйгээр Зарахемлагийн нутаг хүртэл тэднийг харгалзах нь бидний хувьд зайлшгүй болов; мөн түүнчлэн бид леменчүүдээс авсан нь байсан хэдий ч, бидний хүнсний хангамжууд хүмүүсийн маань хэрэгцээнээс илүү хангалттай байсангүй.

16 Мөн эдүгээ, ийм осолтой

нөхцөл байдалд, дайны эдгээр олзлогдогсдын талаар шийдвэрлэх нь маш ноцтой зүйл болов; гэсэн хэдий ч, бид тэднийг Зарахемлагийн нутаг уруу илгээхээр шийдвэрлэв; тиймийн тул бид хүмүүсээсээ нэг хэсгийг сонгон авч, мөн тэдэнд хоригдлуудаа даалгаж, Зарахемла нутаг уруу хүргэхийг тушаав.

17 Гэвч улиран тохиох дор маргааш нь тэд эргэж ирэв. Мөн эдүгээ болгоогтун, бид тэднээс хоригдлуудын талаар асуусангүй; учир нь болгоогтун, леменчүүд бидний дээр байв, мөн тэд биднийг тэдний гарт орохоос аврахаар цагаа олж эргэж ирэв. Учир нь болгоогтун, Амморон тэдэнд дэмжлэг болгон хүнсний шинэ хангамжууд мөн түүнчлэн олон тооны цэрэг эрс илгээсэн байв.

18 Мөнхүү улиран тохиох дор хоригдлуудтай хамт бидний илгээсэн тэдгээр эрс, тэд биднийг давамгайлах гэж байхад тэднийг зогсоохоор цагаа олж ирэв.

19 Гэвч болгоогтун, миний хоёр мянга жарын жижиг хэсэг туйлын ширүүн тулалдав; тийм ээ, тэд леменчүүдийн өмнө ухаршгүй байж, мөн тэдний эсрэг зогссон тэд бүгдийг үхэлд хүргэж байв.

20 Мөн манай их цэргийн үлдсэн нь леменчүүдийн өмнө ухрах гэж байхад, болгоогтун, тэрхүү хоёр мянга жар ухаршгүй мөн гуйвшгүй байв.

21 Тийм ээ, мөн тэд зарли-

гийн үг бүрийг яг таг гүйцэтгэхдээ дуулгавартай мөн шаргуу байв; тийм ээ, мөн бүр итгэл бишрэлийнх нь дагуу энэ нь тэдэнд хийгдсэн бөлгөө; мөн “эхчүүд нь тэдэнд заасан хэмээн тэдний надад хэлсэн үгсийг би санаж байв.

22 Мөн эдүгээ болгоогтун, энэ агуу их лялтын төлөө бид өртэй болох тэд болбоос, хоригдлуудыг хүргэхээр сонгогдсон эрчүүд, мөн миний эдгээр хөвгүүд болой; учир нь леменчүүдийг бут цохьсон нь тэд байв; тиймийн тул леменчүүд Мантай хот уруу гэдрэг туугдлаа.

23 Мөн бид Кууманай хотоо хадгалж үлдсэн буюу, мөн бүгд илдэнд устгагдсангүй; гэсэн хэдий ч, бид их хохирол хүлээв.

24 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийг зугтсаны дараа, би тэр даруй үхэгсдийн дундаас шархадсан өөрийн хүмүүсийг авах тушаал өгч, мөн шархыг нь боолгох болгов.

25 Мөнхүү улиран тохиох дор миний хоёр мянга жараас цус алдсанаас ухаан алдаж унасан нь хоёр зуу байлаа; гэсэн хэдий ч, Бурханы сайн сайхны дагуу, мөн бидний үлэмж гайшрал мөн түүнчлэн бүх их цэргийн маань баяслыг төрүүлэн, тэднээс мөхсөн бодгаль “нэгээхэн ч байсангүй; тийм ээ, бас тэдний дунд олон шарх аваагүй нэг ч бодгаль байсангүй.

26 Мөн эдүгээ, тэдний хамгаалагдан үлдсэн нь манай бүх их цэргийн гайхлыг төрүүлж байв, тийм ээ, бидний ах дүүсийн мянга нь алагдсан байхад тэд хэлтрүүлэгдсэн байлаа. Мөн Бурханы гайхамшигт “хүчинд бид үүнийг шударгаар хамааруулж байна, тэд итгэхээр сургагдсан түүндээ итгэх үлэмж “итгэлийнхээ улмаас буюу, үүнд—шударга Бурхан гэж буй, мөн эргэлзээгүй хэн боловч, тэд түүний гайхамшигт хүчээр хамгаалагдан үлдсэн байна гэдэгт бөлгөө.

27 Эдүгээ энэ нь миний тухайлан ярьсан тэдний итгэл байв; тэд залуу, мөн тэдний оюун нь өөрчлөгдөшгүй, мөн тэд Бурханд найдлагаа үргэлж тавьдаг бөлгөө.

28 Мөн эдүгээ улиран тохиох дор бид шархадсан эрчүүдээ тийн сувилсны, мөн үхэгсдээ мөн түүнчлэн леменчүүдийн олон үхэгсдийг оршуулсныхаа дараа, болгоогтун, бид Зарахемла нутаг уруу тэдэнтэй явж эхэлсэн хоригдлуудын тухай Гидээс лавлав.

29 Эдүгээ Гид бол уг нутаг уруу тэднийг харгалзахаар тохоогдсон хэсгийн ерөнхий ахмад байв.

30 Мөн эдүгээ, Гидийн надад хэлсэн үгс нь эдгээр болой: Болгоогтун, бид олзлогдогсодтойгоо хамт Зарахемла нутаг уруу явж эхлэв. Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн буудлыг ажиглахаар

илгээгдсэн, их цэргийнхээ тандуулуудтай бид тааралдав.

31 Мөн тэд бидэнд хашгирч, хэлсэн нь—Болгоогтун, леменчүүдийн их цэрэг Кууманай хотыг чиглэн жагсаж явна; мөн болгоогтун, тэд тэдний дээр бууна, тийм ээ, мөн хүмүүсийг маань устгах болно.

32 Мөнхүү улиран тохиох дор олзлогдогсод маань өөрсдийг нь зоригжуулсан, тэдний хашгирааныг сонсов; мөн тэд бидний эсрэг тэмцэлдэхээр босов.

33 Мөнхүү улиран тохиох дор тэдний эсэргүүцлийн учир бид илдээ тэдний дээр буух болгов. Мөнхүү улиран тохиох дор тэд бөөнөөрөө бидний илдэн дор гүйн ирцгээж, ингэх зуур, тэдний олонх нь алагдав; мөн тэдний үлдсэн нь дайран гарч мөн биднээс зугтаж одов.

34 Мөн болгоогтун, тэднийг зугтахад бид тэднийг гүйцэж чадсангүй, бид Кууманай хотын зүг яаравчлан жагсаж одов; мөн болгоогтун, бид хотыг хадгалан хамгаалахад нь ах дүүстээ тусалж болохын тулд бид цагаа олж ирсэн билээ.

35 Мөн болгоогтун, бид дайснуудынхаа гараас дахин чөлөөлөгдлөө. Мөн Бурханы минь нэр алдаршиг; учир нь болгоогтун, биднийг чөлөөлсөн нь тэр бөлгөө; тийм ээ, бидний төлөө энэ агуу зүйлийг хийсэн нь тэр буюу.

36 Эдүгээ улиран тохиох дор би Хиламан, Гидийн эдгээр үгсийг сонсоод, бид бүгд мөхөхгүй байж болохын тулд, биднийг хамгаалахад үзүүлсэн Бурханы сайн сайхны учир үлэмж баяслаар халгилав; тийм ээ, мөн алагдсан тэдний бодгаль нь Бурханыхаа амралтад “орсон хэмээн найдна би.

БҮЛЭГ 58

Хиламан, Гид мөн Тиамнер нар Мантай хотыг заль мэхээр авав — Леменчүүд ухран зайлав — Аммоны хүмүүсийн хөвгүүд чөлөөт байдал мөн итгэлээ хамгаалахад бат зогссоноороо хадгалагдан үлдэв. Ойролцоогоор мээ 63–62 он.

Мөн болгоогтун, эдүгээ улиран тохиох дор бидний дараагийн зорилго бол Мантай хотыг авах байв; гэвч болгоогтун, өөрсдийн багахан хэсгээр бид тэднийг хотоос гаргаж чадах ямар ч аргагүй байв. Учир нь болгоогтун, тэд бидний урьд нь юу хийснийг санаж байв; тиймийн тул бид тэднийг хориглолтуудаас нь “залилан гаргаж чадсангүй.

2 Мөн тэд бидний их цэргээс илүү олон тоотой байснаас, бид давшин мөн хориглолтонд нь тэднийг дайрч зүрхэлсэнгүй.

3 Тийм ээ, бид эзэмшлийн нутгаасаа буцаан авсан хэс-

гүүдийг хадгалан хамгаалахын тулд өөрсдийн хүмүүсийг ажиллуулах нь бидний хувьд зайлшгүй болов; тиймийн тул бид Зарахемла нутгаас нэмэгдэл хүч мөн түүнчлэн хүнсний шинэ хангамж хүлээн авч болохын тулд, бид хүлээх нь зайлшгүй болов.

4 Мөнхүү улиран тохиох дор би нутгийнхаа захирагчид тийн хүмүүсийнхээ байдлын талаар танилцуулахаар элч илгээв. Мөнхүү улиран тохиох дор бид Зарахемла нутгаас хүнс болон хүч хүлээн авахыг хүлээх болов.

5 Гэвч болгоогтун, ингэх нь бидэнд ашиг багатай байв; учир нь леменчүүд ч түүнчлэн өдрөөс өдөрт их хүч, мөн түүнчлэн хүнсний их нөөц хүлээн авч байв; мөн энэ үед бидний нөхцөл байдал тийн байв.

6 Мөн леменчүүд үе үе бидний эсрэг довтолж, биднийг заль мэхээр устгахаар шийдсэн байв; гэсэн хэдий ч бид, тэдний нуувчнууд тэдний хориглолтуудын учир тэдэнтэй тулалдахаар очиж чадсангүй.

7 Мөнхүү улиран тохиох дор бид эдгээр хэцүү нөхцөл байдалд олон сарын турш, бүр бид хүнс дутагдсанаас эрсдэх дөхтлөө хүлээсэн билээ.

8 Гэвч улиран тохиох дор хоёр мянган эрстэй их цэргээр харгалзуулагдан бидэнд авчрагдсан, бидэнд тусламж болох хүнсийг бид хүлээн авсан билээ; мөн өөрсдийгөө мөн улс орноо дайснуудынхаа гарт орохоос хамгаалахаар,

тийм ээ, тоолшгүй олон байсан тэр дайсантай тэмцэлдэхээр, бидний хүлээн авсан бүх тусламж энэ л юм.

9 Мөн эдүгээ бидний эдгээр хүндрэлүүдийн шалтгааныг, эсвээс тэд бидэнд илүү нэмэгдэл хүч илгээгээгүйн шалтгааныг бид мэдсэн нь үгүй; тиймийн тул бидний уналт мөн бүрмөсөн устгалд хүргэн Бурханы шийтгэлүүд ямар нэгэн байдлаар нутаг дээр минь ирэх буюу хэмээн бид гашуудаж мөн түүнчлэн айдсаар дүүрсэн байв.

10 Тиймийн тул тэрээр биднийг хүчирхэгжүүлж мөн биднийг дайснуудын маань гараас чөлөөлж, тийм ээ, мөн түүнчлэн хүмүүсийнхээ дэмжлэгийн төлөө бид хотуудаа, мөн газар нутгаа, мөн эзэмшлүүдээ хадгалж болох хүчийг бидэнд түүнчлэн өгөөсэй хэмээн бид сэтгэл оюунаа Бурханд хандсан залбиралд юүлсэн болой.

11 Тийм ээ, мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Бурхан минь, тэрээр биднийг чөлөөлөх болно хэмээх баталгаагаар бидэнд зочилсон юм; тийм ээ, үүний хэрээр тэр бидний сэтгэл оюунд амар амгаланг өгч, мөн агуу итгэлийг бидэнд соёрхож, мөн биднийг түүгээр дамжин ирэх чөлөөлөлтөндөө найдах болгосон билээ.

12 Мөн бид хүлээн авсан тэр багахан хүчиндээ зоригжин, мөн дайснуудаа ялахаар, мөн газар нутгаа, мөн эзэмшлүүдээ, мөн эхнэр, мөн

хүүхдүүдээ, түүнчлэн “эрх чөлөөний хөдөлгөөнөө хадгалан” хамгаалахаар хөдөлшгүй хатуу шийдсэн байв.

13 Мөн бид тийн Мантай хотод байсан леменчүүдийн эсрэг бүх хүчээрээ давшив; мөн уг хотын дэргэдэх аглаг буйдын захад ойролцоо майхнуудаа босгов.

14 Мөнхүү улиран тохиох дор маргааш нь, бидний уг хотын дэргэдэх аглаг буйдын захад байсныг леменчүүд үзээд, тэд их цэргийн маань тоо мөн хүчийг олж мэдэж болохын тулд бидний эргэн тойронд тандуулуудаа илгээв.

15 Мөнхүү улиран тохиох дор тооныхоо улмаас, бидний хүчтэй бишийг тэд үзээд, мөн тэд бидний эсрэг тулалдахаар гарч ирэн мөн биднийг хөнөөхгүй бол бид тэднийг дэмжлэгээс нь салгах болуузай хэмээн айж, мөн түүнчлэн өөрсдийнхөө олон тооны цэргүүдээрээ биднийг амархан устгаж чадна хэмээн бодсоны учир, тиймийн тул бидний эсрэг тулалдахаар гарч ирэхээр тэд бэлтгэлүүдийг хийж эхлэв.

16 Мөн тэд бидний эсрэг гарч ирэхээр бэлтгэлүүдийг хийж байсныг бид хараад, болгоогтун, би Гидийг цөөн тооны хүмүүстэй, өөрийгөө аглаг буйдад нуух, мөн түүнчлэн Тиамнерыг мөн цөөн тооны хүмүүстэй өөрсдийгөө түүнчлэн аглаг буйдад нуух болгов.

17 Эдүгээ Гид мөн түүний хүмүүс баруун талд мөн бусад нь зүүн талд байв; мөн тэд тийн өөрсдийгөө нууцалсны дараа, болгоогтун, би их цэргийнхээ үлдсэнтэй нь, анх майхнаа босгосон газраа леменчүүд тулалдахаар гарч ирэх цагт бэлтгэн үлдэв.

18 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд бидний эсрэг олон тооны их цэрэгтэйгээ гарч ирэв. Мөн тэд ирээд мөн илдтэйгээ бидний дээр буух гэж байхад нь, би хүмүүсээ, надтай байсан тэднийг, аглаг буйд тийш ухрах болгов.

19 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд биднийг хөнөөж болохын тулд тэд биднийг гүйцэх үлэмж хүсэлтэй байсны улмаас, тэд их хурдтайгаар бидний араас нэхсэн болой; тиймийн тул тэд биднийг аглаг буйд тийш дагав; мөн бид Гид мөн Тиамнер нарын дундуур өнгөрч, үүний хэрээр тэд леменчүүдээр илрүүлэгдсэнгүй.

20 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийг өнгөрсний дараа, өөрөөр хэлбэл их цэргийг нь өнгөрмөгц, Гид мөн Тиамнер нар нуугдсан газруудаасаа босож, мөн леменчүүдийн тандуулуудыг хотод эргэн очуулахгүйн тулд тэднийг тасалсан болой.

21 Мөнхүү улиран тохиох дор тэд тэднийг тасалсныхаа дараа, тэд хот уруу гүйж мөн хотыг харгалзахаар үлдсэн харуулууд дээр буув, үүнчлэн

тэд тэднийг устгаж мөн хотыг эзэмшилдээ авсан болой.

22 Эдүгээ леменчүүд зөвхөн цөөн хэдэн харуулуудаас бусдыг нь, аглаг буйд тийш бүхэл их цэргээ зайцуулан удирдагдахаар болгосон учир энэ явдал тохиолдов.

23 Мөнхүү улиран тохиох дор Гид мөн Тиамнер нар энэ маягаар тэдний хориглолтуудыг эзэмшилдээ олж авсан байв. Мөнхүү улиран тохиох дор Зарахемлагийн нутгийн зүг аглаг буйдад ихэд аялсны дараа, бид аян замаа хөөв.

24 Мөн леменчүүд өөрсдийгөө Зарахемлагийн нутгийн зүг жагсан явж буйгаа үзээд, тэднийг устгалд хүргэх төлөвлөгөө хийгдсэн болов уу хэмээн тэд үлэмж их айв; тиймийн тул тэд аглаг буйд тийш, тийм ээ, бүр өөрсдийн ирсэн тэрхүү замаар буцаад буцан ухарч эхлэв.

25 Мөн болгоогтун, энэ нь шөнө байв, мөн тэд майхнуудаа босгосон байлаа, учир нь леменчүүдийн ерөнхий ахмадууд нифайчууд алхсаныхаа учир ядарсан байгаа хэмээн бодсон аж; мөн тэдний их цэргийг бүхэлд нь өмнөө байсан хэмээн бодсон учир, тиймийн тул тэд Мантай хотын талаар огт бодсонгүй.

26 Эдүгээ улиран тохиох дор шөнө болоход, би хүмүүсээ унталгүй, харин тэд өөр нэг замаар Мантайн нутгийн зүг урагшлан, жагсан явах болгов.

27 Мөн бид шөнийн цагт жагсан явсан учир, болгоогтун, маргааш нь бид леменчүүдийн цаана нь гарч, ингэснээр бид тэднээс урьд Мантайн хотод хүрч ирсэн бөлгөө.

28 Мөн тийн улиран тохиох дор, энэ зальт аргаар бид Мантай хотыг цус урсгалгүйгээр эзэмшилдээ авав.

29 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн их цэрэг уг хотын дэргэд хүрч ирээд, мөн бид тэдэнтэй тулгарахаар бэлтгэснийг үзээд, тэд үлэмж цочирдон мөн их айдсаар балмагдаж, ингээд тэд аглаг буйд тийш зугтав.

30 Тийм ээ, мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн их цэрэг уг нутгийн энэ хэсгээс гарч зугтсан болой. Гэвч болгоогтун тэд, уг нутгаас олон эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийг өөрсөдтэйгөө авч гарав.

31 Мөн леменчүүдээр эзлэгдсэн “тэдгээр хотууд, бүгдээрээ энэ үед бидний эзэмшилд байна; мөн эцгүүд маань мөн манай эмэгтэйчүүд мөн хүүхдүүд маань, леменчүүдээр олзлогдон аваачигдсан тэднээс бусад нь бүгд, гэртээ эргэн ирцгээж байлаа.

32 Гэвч болгоогтун, тийм агуу олон хотыг мөн тийм агуу эзэмшлүүдийг хадгалан хамгаалахад их цэрэг маань бага байв.

33 Гэвч болгоогтун, Бурхандаа, тэдгээр нутгуудын дээрх ялалтыг бидэнд өгсөн түүнд

бид найдна, үүний хэрээр бид өөрсдийнх байсан тэдгээр хотууд мөн тэдгээр нутгуудыг авсан билээ.

34 Эдүгээ засгийн газар бидэнд илүү нэмэгдэл хүч өгөөгүйн шалтгааныг бид мэдэхгүй байна; бидэнд ирсэн тэдгээр хүмүүс ч бас бид яагаад илүү их нэмэгдэл хүч хүлээн аваагүйг мэдсэнгүй.

35 Болгоогтун, та нар амжилтгүй байж, мөн та нар нутгийн тэр хэсэгт бүх хүчийг аваачсан байж магадгүй юм; хэрэв тэгсэн бол, бид бувтналдах хүсэлгүй байна.

36 Мөн хэрэв тэгээгүй аваас, болгоогтун, засгийн газарт “тэрслүү үзэл байгаагаас тэд бидэнд нэмэгдэл хүмүүсийг туслуулахаар илгээхгүй байна хэмээн бид айж байна; учир нь тэд тэдний илгээснээс илүү олон тоотойг бид мэдэж байна.

37 Гэвч болгоогтун, энэ хамаагүй — бид их цэрэг маань сул дорой ч гэсэн, Бурхан биднийг, тийм ээ, мөн дайснуудын маань гараас “чөлөөлөх болно гэдэгт бид найдна.

38 Болгоогтун, энэ бол хорин ес дэх оны төгсгөл, мөн бид өөрсдийн нутгуудыг эзэмшин байна; мөн леменчүүд Нифайн нутаг тийш зугтсан байлаа.

39 Мөн миний өндрөөр үнэлэн ярьсан, Аммоны хүмүүсийн тэдгээр хөвгүүд надтай хамт Мантай хотод байна;

мөн Их Эзэн тэднийг дэмжсэн, тийм ээ, мөн тэднийг илдэнд унахаас хамгаалсан, үүний үр дүнд бүр “нэг ч бодгаль эрсдээгүй болой.

40 Гэвч болгоогтун, тэд олон шарх олсон; гэсэн хэдий ч тэд Бурханаар чөлөөлөгдсөн “эрх чөлөөндөө бат зогсож байна; мөн тэд Их Эзэн Бурханаа өдрөөс өдөрт дурсан санахдаа хичээнгүй байдаг; тийм ээ, тэд түүний дүрмүүдийг, мөн түүний тогтоолуудыг, мөн түүний зарлигуудыг үргэлж дагахыг чармайдаг; мөн ирэх тэр зүйлийн талаарх бошиг-лолуудад тэдний итгэл хүчтэй байлаа.

41 Мөн эдүгээ, хайрт ах Моронай минь, биднийг гэтэлгэсэн мөн биднийг чөлөөтэй болгосон Их Эзэн бидний Бурхан, та нарыг үргэлж дэргэдээ байлгах болтугай; тийм ээ, мөн тэрээр энэ хүмүүсийг таалалдаа багтааг, тиймээс бүр та нар леменчүүд биднээс авсан, бидний дэмжлэгийн төлөө байсан тэр бүгдийг эзэмшилдээ олж авахад амжилттай байх болтугай. Мөн эдүгээ, болгоогтун, би захидлаа дуусгая. Би бол Алмагийн хүү, Хиламан болой.

БҮЛЭГ 59

Моронай Хиламаны цэргийн хүчийг зузаатгахыг Пахоранаас гуйв — Леменчүүд Нифайха хотыг эзлэв — Моронай засгийн

газарт уурлав. Ойролцоогоор мээ 62 он.

Эдүгээ улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын гучдугаар онд, Моронай Хиламаны “захидлыг хүлээн авч, уншсаныхаа дараа, Хиламаны аз жаргалын улмаас үлэмж баясав, тийм ээ, алдагдсан тэдгээр нутгуудыг олж авахад түүний олсон үлэмж их амжилтын учир бөлгөө.

2 Тийм ээ, мөн тэд ч түүнчлэн баясаж болохын тулд, тэрээр өөрийнх байсан тэр хэсгийнхээ эргэн тойрны бүх нутагт дахь өөрийн бүх хүмүүст үүнийг мэдүүлэв.

3 Мөнхүү улиран тохиох дор Хиламан дахин олж авахдаа тийм гайхамшигтайгаар дэмжигдсэн уг нутгийн тэр хэсгийг хадгалан хамгаалахад хялбар дөхөм байж болохын тулд, Хиламаныг өөрөөр хэлбэл түүний их цэргийг хүчирхэгжүүлэхээр, хүмүүсийг нэгтгэн цуглуулахыг хүсч тэрээр тэр даруй “Пахоранд захидал илгээв.

4 Мөнхүү улиран тохиох дор Моронай энэ захидлыг Зарахемлагийн нутагт илгээгээд, тэрээр леменчүүд тэднээс авсан тэр хотууд мөн эзэмшлүүдийн үлдсэнийг нь олж авч болохын тулд дахин төлөвлөгөө зохиож эхлэв.

5 Мөнхүү улиран тохиох дор Моронай ийн леменчүүдийн эсрэг тулалдахаар явах

бэлтгэлүүдийг хийж байх зуур, болгоогтун, Моронай хотоос мөн Лихай хотоос мөн Морриантан хотоос нэгдэн цугларсан Нифайхагийн хүмүүсийг леменчүүд довтлов.

6 Тийм ээ, бүр Мантай нутгаас мөн эргэн тойрных нь нутгаас зугтахаас аргагүйд хүргэгдсэн тэд ирж мөн нутгийн энэ хэсэг дэх леменчүүдтэй нэгдсэн байв.

7 Мөн ийн тэд үлэмж олон тоотой байв, тийм ээ, мөн өдрөөс өдөрт нэмэгдэл хүч хүлээн авч байсан учир, Амороны тушаалаар тэд Нифайхагийн хүмүүсийн эсрэг ирж, мөн тэд үлэмж их аллагаар тэднийг хөнөөж эхлэв.

8 Мөн тэдний их цэрэг нь тийм олон тоотой байснаас Нифайхагийн хүмүүсийн үлдэгдэл тэдний өмнө зугтахаас аргагүй болжээ; мөн тэд ирж мөн бүр Моронайн их цэрэгт нэгдэв.

9 Мөн эдүгээ леменчүүдээс үүнийг дахин авах гэснээс уг хотыг тэдний гарт орохоос хамгаалах нь илүү амархныг мэдсэн учир, уг хотыг хамгаалахад нь хүмүүст туслуулахаар Нифайха хот тийш хүмүүс илгээгдэх ёстой хэмээн Моронай бодсоноос, тэд хотыг амархан хадгалан хамгаалах болно хэмээн тэрээр боджээ.

10 Тиймийн тул тэрээр өөрийн буцааж авсан газруудаа хадгалан хамгаалахаар бүх хүчийг өөртөө авч үлдэв.

11 Мөн эдүгээ, Нифайха хот алдагдсаныг Моронай хараад, тэрээр үлэмж харамсаж, мөн хүмүүсийн ёс бус байдлын учир, тэд ах дүүсийнхээ гарт орох болов уу хэмээн эргэлзэж эхлэв.

12 Эдүгээ энэ нь түүний бүх ерөнхий ахмадуудын байдал байв. Тэд хүмүүсийн ёс бусын учир эргэлзэж мөн түүнчлэн гайхашран байв, мөн энэ нь тэдний дээрх леменчүүдийн амжилтын учир болой.

13 Мөнхүү улиран тохиох дор, улс орныхоо эрх чөлөөний талаарх тэдний “хайхрамжгүйн учир Моронай засгийн газарт уурлаж байв.

БҮЛЭГ 60

Моронай их цэргийн талаарх засгийн газрын хайнга байдлын талаар Пахоранд гомдоллов— Зөв шударгыг үйлдэгчид алагдахыг Их Эзэн тэвчдэг— Нифайчууд өөрсдийгөө дайснаудаасаа чөлөөлөхийн тулд бүх хүчээ мөн бүх аргаа хэрэглэх ёстой— Моронай их цэрэгт нь тусламж хангагдахгүй аваас засгийн газрын эсрэг тулалдахаар заналхийлэв. Ойролцоогоор мэв 62 он.

Мөнхүү улиран тохиох дор тэрээр Пахоран гэгдсэн тэр, нутгийн захирагчид дахин бичив, мөн түүний бичсэн үгс нь эдгээр болой, өгүүлсэн нь: Болгоогтун, Зарахемла хот дахь, уг нутгийн дээрх захирагч мөн “ерөнхий шүүгч

болох Пахоранд, мөн түүнчлэн энэ хүмүүсээр энэхүү дайны хэргийг засаглан мөн удирдахаар сонгогдсон тэд бүгдэд би захидлаа хандуулж байна.

2 Учир нь болгоогтун, зэмлэл болгон тэдэнд хэлэх зарим зүйл надад байна; учир нь болгоогтун, эрчүүдийг нэгтгэн цуглуулахаар, мөн тэднийг сэлмээр, мөн илдээр, мөн бүхий л төрлийн дайны зүйл бүрийн зэвсгүүдээр зэвсэглэхээр, мөн леменчүүд бидний нутагт аль ч хэсгээр орж ирлээ гэсэн, тэдний эсрэг тэднийг илгээхээр та нар томилогдсоноо та нар өөрсдөө мэднэ.

3 Мөн эдүгээ болгоогтун, би өөрөө мөн түүнчлэн миний хүмүүс, мөн түүнчлэн Хиламан болон түүний хүмүүс үлэмж агуу зовлон зүдгүүр; тийм ээ, бүр өлсгөлөн, цангалт, мөн туйлдалт, мөн бүх зүйлийн төрөл бүрийн зүдрэлүүдийг амссаныг би та нарт хэлье.

4 Гэвч болгоогтун, хэрэв бидний зовсон нь үүгээр дууссан бол бид бувтналдаж мөн гомдоллохгүй байх сан.

5 Гэвч болгоогтун, хүмүүсийн маань дундах аллага агуу их байв; тийм ээ, хэрэв та нар их цэрэгт маань хангалттай хүчээр мөн дэмжлэгээр тэдэнд тус дэм үзүүлсэн бол өөрөөр байж болох байхад, мянга мянга нь илдэнд унагагдлаа. Тийм ээ, бидэнд

хандсан хайхрамжгүй байдал тань нэгэд их байлаа.

6 Мөн эдүгээ болгоогтун, энэхүү үлэмж их хайхрамжгүй байдлын шалтгааныг бид мэдэх хүсэлтэй байна; тийм ээ, бодлогогүй байдлын чинь шалтгааныг бид мэдэхийг хүсч байна.

7 Дайснууд чинь та нарын эргэн тойронд үхлийн үйлийг тарьж байхад, та нар дүйнгэ, бодлогогүйгээр сэнтий дээрээ залрахыг бодож чадна гэж үү? Тийм ээ, тэд ах дүүсээс тань мянга мянгыг хөнөөж байхад шүү дээ—

8 Тийм ээ, бүр хамгааллын төлөө та нар өөд харсан тэднийг, тийм ээ, та нар тэднийг дэмжиж болох байсан тэднийг, тийм ээ, та нар тэднийг хүчирхэгжүүлэхээр, тэдэнд их цэрэг илгээж, мөн тэднээс мянга мянгыг нь илдэнд унахаас аварч болох байсан тэрхүү нөхцөл байдалд та нарыг тавьсан тэднийг.

9 Гэвч болгоогтун, энэ нь бүгд бус—та нар хүнсээ тэднээс харамласан, үүний хэрээр энэ хүмүүсийн аз жаргалын төлөө гэсэн өөрсдөд нь байсан агуу хүслүүдийнхээ учир олон нь тулалдаж мөн тэд цусаа шавхан амиа алдсан буюу; тийм ээ, мөн та нарын тэдэнд хандсан үлэмж агуу хайхрамжгүй байдлын учир, тэд өлсгөлөнгөөр “мөхөх гэж байхдаа тэд үүнийг хийсэн билээ.

10 Мөн эдүгээ, хайрт ах дүүс минь—учир нь та нар хайрт хэмээн дуудагдахаар байвал зохино; тийм ээ, мөн та нар энэ хүмүүсийн аз жаргал хийгээд эрх чөлөөний төлөө өөрсдийгөө илүү шаргуу хөдөлгөх ёстой байсан юм; гэвч болгоогтун, та нар тэднийг үл хайхарсан, үүний хэрээр мянга мянгийн цус та нарын толгой дээр өс хонзонгийн учир ирэх болно; тийм ээ, учир нь тэдний бүх хашгиралдаан, мөн тэдний бүх зүдрэлүүд Бурханд мэдэгдсэн бөлгөө—

11 Болгоогтун, та нар сэнтий дээрээ заларч, мөн Бурханы үлэмж сайн сайхны учир та нар өөрсдөө юу ч хийхгүй байхад, тэрээр та нарыг чөлөөлнө хэмээн та нар бодож чадна гэж үү? Болгоогтун, хэрэв та нар ийн боддог бол та нар хоосныг боджээ.

12 Ах дүүсээс чинь ийм олон алагдсан нь өөрсдийнх нь ёс бусын учир хэмээн та нар “бодно уу? Би та нарт хэлнэ, хэрэв та нар ийн бодсон аваас та нар хоосныг боджээ; учир нь би та нарт хэлнэ, илдээр унагаагдсан нь олон байна; мөн болгоогтун энэ бол та нарыг яллах ял бөлгөө.

13 Учир нь, ёс бусыг үйлдэгчдийн дээр өөрийнх нь шударга ёс мөн шүүлт ирж болохын тулд “зөв шударгыг үйлдэгсэд хөнөөгдөхийг Их Эзэн хүлцэн тэвчдэг билээ;

тиймийн тул тэд алагдсан учир зөв шударгыг үйлдэгсэд алдагдсан хэмээн та нар бодох хэрэггүй; гэвч болгоогтун, тэд Их Эзэн Бурханыхаа амралтад орох болно.

14 Мөн эдүгээ болгоогтун, би та нарт хэлнэ, тэдний үлэмж залхуу хойргынх нь, тийм ээ, бүр засгийн газрын маань залхуу хойрго байдал, мөн ах дүүсдээ хандсан тэдний, тийм ээ, алагдсан тэдний зүг хандсан тэрхүү үлэмж хайхрамжгүй байдлын учир энэ хүмүүсийн дээр Бурханы шүүлтүүд ирэх болов уу хэмээн би үлэмж айж байна.

15 Учир нь хэрэв бидний дээрх удирдагчдаас анх эхэлсэн тэр “ёс бус нь байгаагүй аваас, тэд биднийг давах хүч хуримтлуулж чадахгүй байхын тулд бид дайснуудаа сөрөн зогсож чадах байсан билээ.

16 Тийм ээ, өөрсдийн маань дунд гарсан тэрхүү “дайнаас болоогүй сэн бол; тийм ээ, өөрсдийнхөө дунд их цус урсахад хүргэсэн тэрхүү, “хааныг хүсэгч хүмүүс байгаагүй бол; тийм ээ, өөр хоорондоо тэмцэлдэж байх тэр цагтаа, хэрэв бид урьд нь тэгснийхээ адилаар хүчээ нэгтгэсэн аваас; тийм ээ, хэрэв хааныг хүсэгч хүмүүст биднийг давах хүч чадлыг мөн эрх мэдлийг хүссэн нь байгаагүй аваас; тэд өөрсдийн маань дунд ийм их цус урсалтын шалтгаан болж, бидний эсрэг илд барихынхаа

оронд, бидний эрх чөлөөний хөдөлгөөнд үнэнч байж, мөн бидэнтэй нэгдэж мөн дайснуудын маань эсрэг явсан бол; тийм ээ, хэрэв бид Их Эзэний хүчээр тэдний эсрэг явсан бол, бид дайснуудаа сарниулах байв, учир нь энэ нь түүний үгийн биелэлтийн дагуу хийгдэх байсан билээ.

17 Гэвч болгоогтун, эдүгээ леменчүүд бидний дээр ирж, нутгуудыг маань эзэмшилдээ авч, мөн тэд хүмүүсийг маань, тийм ээ, эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийг маань илдээр хөнөөж, мөн түүнчлэн тэднийг боолчлолд аваачиж, тэднийг бүх л төрлийн зүдгүүрүүдийг тэвчихэд хүргэж байна, мөн энэ нь хүч чадал болон эрх мэдэл хайгч тэдний, тийм ээ, бүр тэдгээр хааныг хүсэгч хүмүүсийн агуу ёс бусын учир болой.

18 Гэвч энэ хэргийн талаар яагаад би ихийг хэлэх ёстой билээ? Учир нь та нар өөрсдөө эрх мэдлийг эрэлхийлж байгаа эсэхийг бид мэдэхгүй юм. Та нар түүнчлэн улс орноосоо урвагч эсэхийг бид мэдэхгүй юм.

19 Эсвээс та нар бидэнд хүнс мөн түүнчлэн их цэргийг маань хүчирхэгжүүлэх эрсийг илгээх болгодоггүй нь та нар улс орны маань зүрхэнд мөн хамгаалалтаар хүрээлэгдсэн байгаа учраас, та нар биднийг эс хайхарч байна уу?

20 Та нар Их Эзэн Бурханыхаа зарлигуудыг мартсан уу?

Тийм ээ, та нар эцэг өвгөдөө боолчлолд байсныг мартсан уу? Бид дайснуудынхаа гараас чөлөөлөгдөж байсан олон тохиолдлыг та нар мартсан уу?

21 Эсвээс Их Эзэн бидэнд соёрхсон арга замуудыг эс хэрэглэн, мөн биднийг сэнтий дээрээ заларч байхад Их Эзэн биднийг бас л чөлөөлнө хэмээн та нар бодно уу?

22 Тийм ээ, нутгийн хил дээр эргэн тойронд мянга мянга нь илдэнд унагаагдаж, тийм ээ, шархдаж мөн цус алдаж байхад, залхаг байдалд залрах тэднийг мянга мянгаар, тийм ээ, хэдэн арван мянгаар нь хүрээлүүлэн байхдаа, та нар ч түүнчлэн залхаг байдалд заларсан байх уу?

23 Хөдөлгөөнгүй суугаад мөн эдгээр зүйлийг харж байх зуур Бурхан та нарыг гэмгүй хэмээн үзэх болно гэж та нар бодно уу? Болгоогтун би та нарт хэлнэ, Үгүй. Эдүгээ “дотоод хэсэг нь эхлээд цэвэршигдэж, мөн тэгээд гадаад хэсэг нь түүнчлэн цэвэршигдэх болно хэмээн Бурхан хэлснийг та нар санаасай хэмээнэ би.

24 Мөн эдүгээ, та нар үйлдсэнээ наманчилж, мөн идэвхийлэн мөн хийж эхлэн, мөн бидэнд мөн түүнчлэн Хиламанд, тэрээр буцаан авсан улсын маань тэдгээр хэсгийг дэмжиж болохын тулд, мөн түүнчлэн бид эдгээр хэсгүүд дэх эзэмшлүүдийнхээ үлдсэнийг нь буцаан авч

болохын тулд, бидэнд хүнс мөн эрсийг илгээхгүй бол, болгоогтун бид эхлээд дотоод хэсгээ, тийм ээ, бүр засгийн газрынхаа удирдагчдыг эхлээд цэвэрлэхээс нааш лемэнчүүдтэй бид цаашид тэмцэлдэхгүй байх нь зүйд нийцэх ажгуу.

25 Мөн та нар миний захидалдаа дурдсаныг зөвшөөрч, мөн “эрх чөлөөнд үнэнч байдлыг надад илэрхийгээр үзүүлж, мөн их цэргийг маань хүчирхэгжүүлж мөн бэхжүүлэхээр чармайн оролдож, мөн тэдэнд дэмжлэг болгон тэдэнд хүнс өгөхгүй аваас, болгоогтун, би эрх чөлөөг хүсэгч хүмүүсийнхээ хэсгийг нутгийнхаа энэ хэсгийг хадгалан хамгаалуулахаар үлдээх болно, мөн бусад ямар ч хүч тэдний эсрэг үйлдэж чадахгүйн тулд тэдний дээр би Бурханы хүч чадал мөн адислалуудыг үлдээх болно —

26 Мөн энэ нь тэдний өөрсдийнх нь зүдгүүрүүд дэх гэвчээрийн мөн тэдний үлэмж итгэлийн учир болой —

27 Мөн та нар дээр би очих болно, мөн хэрэв та нарын дунд эрх чөлөөг хүсч буй хэн нэг нь байвал, тийм ээ, хэрэв эрх чөлөөний бүр оч ч болов үлдсэн бол, бүр хүч чадал болон эрх мэдлийг шударга бусаар эзлэхийг хүссэн тэд бүрмөсөн устах хүртэл болгоогтун би та нарын дунд бослого гаргахаар өдөөх болно.

28 Тийм ээ, болгоогтун та

нарын хүч чадал бас эрх мэдлээс ч би айдаггүй, гэвч миний айх тэр нь “Бурхан минь билээ; мөн эх орныхоо талыг батлан хамгаалахаар илдээ агссан минь түүний зарлигуудын дагуу билээ, мөн бид ийм их хохирол үзсэн нь та нарын алдсуудын улмаас юм.

29 Болгоогтун улс орноо мөн багачуудаа хамгаалахад та нар өөрсдийгөө дайчлахгүй аваас, шударга ёсны “илд та нарын дээр далайгаастай байх цаг болжээ, тийм ээ, цаг нь ирсэн байна; тийм ээ, мөн энэ нь та нарын дээр бууж, тэр ч байтугай бүр бүрмөсөн устгалд чинь хүртэл та нарт зочлох болно.

30 Болгоогтун, би та бүгдээс тусламж хүлээж байна; мөн, та нар бидний дэмжлэгийн төлөө ажиллахгүй аваас, болгоогтун, би та нар дээр, бүр Зарахемла нутагт очиж, мөн та нарыг илдээр цохих болно, үүний хэрээр та нар цаашид энэ хүмүүс эрх чөлөөний хөдөлгөөнд хөгжихөд нь саад болох хүчтэй байж чадахгүй.

31 Учир нь болгоогтун, та нарыг амьдарч мөн түүний зөв шударга хүмүүсийг устгахаар алдсууддаа хүчтэй болохыг тань Их Эзэн тэвчихгүй.

32 Болгоогтун, та нарын алдас энэ дэлхийн нэр алдар болон хоосон зүйлийг хайрлах хайраас чинь шалтгаалж байгаа бол, эцэг өвгөдийнх нь уламжлал тэдний үзэн ядалтыг бий болгож, тийм ээ, мөн

энэ нь биднээс тэрсэлсэн тэднээр хэд дахин нэмэгдсэн байхад, Их Эзэн леменчүүдийн дээр буруушаалтуудыг ноогдуулж мөн та нарыг хэлтрүүлэх болно хэмээн та нар бодож чадах уу?

33 Та нар Бурханы хуулиудыг зөрчдөгөө мэднэ, мөн та нар тэдгээрийг хөл дороо дэвсэлдгээ мэднэ. Болгоогтун: Хэрэв та нарын томилсон захирагчид чинь нүглүүдээ мөн алдсуудаа наманчлахгүй аваас, та нар тэдний эсрэг тулалдахаар явах болно хэмээн Их Эзэн надад хэлдэг.

34 Мөн эдүгээ болгоогтун, Бурханыхаа зарлигуудыг би дагана хэмээн хийсэн тэрхүү гэрээний дагуу Моронай би албадуулагдсан болой; тиймийн тул та нар Бурханы үгийг дагаасай, мөн надад мөн түүнчлэн Хиламанд хүнснээсээ болон хүмүүсээсээ яаралтай илгээгээсэй хэмээнэ би.

35 Мөн болгоогтун, хэрэв та нар үүнийг хийхгүй аваас би та нар дээр яаралтай очно; учир нь болгоогтун, биднийг өлсгөлөнгөөр мөхөхийг Бурхан тэвчихгүй; тиймийн тул хэрэв энэ нь бүр илдээр хийгдэх ёстой болсон ч та нарын хүнснээс тэрээр бидэнд өгөх болно. Эдүгээ та нар Бурханы үгийг биелүүлэхээ мэдээрэй.

36 Болгоогтун, би бол Моронай, та нараар тохоогдсон ерөнхий ахмад. Би удирдан захирах хүчийг бус, харин үүнийг устган зайлуулахыг

“эрэлхийлнэ. Би дэлхийн нэр төрийг эрэлхийлдэггүй, харин Бурханыхаа алдар сууг мөн улс орныхоо эрх чөлөө мөн аз жаргалыг болой. Мөн би захидлаа ийн дуусгая.

БҮЛЭГ 61

Пахоран засгийн газрыг эсэргүүцсэн бослого мөн эсэргүүцлийн тухай Моронайд ярив — Хааныг хүсэгч хүмүүс Зарахемлаг эзэлж, леменчүүдтэй холбоотон болов — Пахоран эсэргүүцэгчдийн эсрэг цэргийн хүчний тусламж гуйв. Ойролцоогоор мээ 62 он.

Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор Моронай өөрийн захидлыг ерөнхий захирагчид илгээснээс хойш удалгүй, тэрээр ерөнхий захирагч “Пахоранаас захидал хүлээн авав. Мөн түүний хүлээн авсан үгс нь эдгээр болой:

2 Энэ нутгийн ерөнхий засаглагч болох Пахоран, би, эдгээр үгсийг их цэргийн дээрх ерөнхий ахмад Моронайд илгээж байна. Болгоогтун, би чамд хэлнэ, Моронай, би та нарын их “зүдгүүрүүдэд баясдаггүй, тийм ээ, энэ нь сэтгэлийг минь шаналгаж байна.

3 Гэвч болгоогтун, та нарын зүдгүүрүүдэд баясах тэд буй, тийм ээ, үүний хэрээр тэд миний эсрэг мөн түүнчлэн миний хүмүүсээс “эрх чөлөөг хүсэгч хүмүүс болох тэдний эсрэг эсэргүүцэлд босч байна,

тийм ээ, мөн боссон тэд үлэмж олон тоотой бөлгөө.

4 Мөн надаас шүүлтийн суудлыг авахыг эрэлхийлсэн тэд бол энэ агуу алдсын шалтгаан юм; тодруулбал тэд агуу зусардалт хэрэглэж, мөн тэд олон хүмүүний зүрх сэтгэлийг зайцуулан удирдсан нь бидний дундах гашуун зовлонгийн шалтгаан байх болно; тэд хүнсийг маань саатуулж, мөн эрх чөлөөг хүсэгч хүмүүсийг маань сүрдүүлснээс тэдгээр нь та нар дээр очоогүй.

5 Мөн болгоогтун, тэд намайг өөрсдийнхөө өмнөөс зайлуулж, мөн би Гидеоны нутагт, би дагуулж чадах бүх эрчүүдтэйгээ хамт зугтаж ирлээ.

6 Мөн болгоогтун, уг нутгийн энэ хэсэг даяар би тунхаг илгээсэн билээ; мөн болгоогтун, улс орноо мөн “эрх чөлөөгөө батлан хамгаалахад мөн бидний эсрэг үйлдэгдсэнээс өшөө авахад, зэвсэг агсахаар тэд өдрөөс өдөрт нэмэгдэн цуглацгааж байна.

7 Мөн тэд бидэнд ирж, үүнчлэн бидний эсрэг эсэргүүцэлд босогчид илэрхийгээр эсэргүүцэгдэв, тийм ээ, үүний хэрээр тэд биднээс айж мөн бидний эсрэг тулалдахаар ирж зүрхэлсэнгүй.

8 Тэд Зарахемла нутгийг, өөрөөр хэлбэл уг хотыг эзэмшилдээ авлаа; тэд дээрээ хааныг тохоож, мөн тэрээр леменчүүдийн хаанд бичжээ,

үүндээ тэрээр түүнтэй холбоотон болон нэгдсэн ажээ; энэ хуйвалдаандаа тэрээр Зарахемла хотыг хадгалан хамгаалахыг зөвшөөрсөн аж, ийн хадгалан хамгаалснаар үлдсэн бүх нутгийг эзлэн авах бололцоог леменчүүдэд олгож, мөн леменчүүдэд тэд ялагдах үед энэ хүмүүсийн дээр өөрөө хаанаар тохоогдох болно хэмээн тэр боджээ.

9 Мөн эдүгээ, чи захидалдаа намайг буруутгажээ, гэвч энэ нь хамаагүй; би уурлаагүй, харин сэтгэлийн чинь агуу ихэд баясна. Пахоран, миний бие хүмүүсийнхээ эрх хийгээд чөлөөт байдлыг хадгалж болохын тулд зөвхөн шүүлтийн суудлаа авч үлдэхээс өөр хүчийг би эрэлхийлдэггүй. Бурхан биднийг “чөлөөтэй болгосон тэрхүү эрх чөлөөнд бодгаль минь бат зогсоно.

10 Мөн эдүгээ, болгоогтун, бид ёс бусыг, бүр цус урсгах хүртлээ эсэргүүцэх болно. Хэрэв леменчүүд нутаг дээрээ үлдвэл, бид тэдний цусыг урсгахгүй.

11 Хэрэв тэд бидний эсрэг эсэргүүцэлд босохгүй мөн илд агсахгүй аваас бид ах дүүсийнхээ цусыг урсгахгүй.

12 Хэрэв энэ нь Бурханы шударга ёсонд шаардагдсан аваас, өөрөөр хэлбэл хэрэв тэр бидэнд түүнчлэн үйлдэхийг зарлигласан аваас бид өөрсдийгөө боолчлолын буулганд харьяалуулах болно.

13 Гэвч болгоогтун тэрээр

өөрсдийгөө дайснууддаа харьяалуулахыг бус, харин бид түүнд “найдлагаа тавихыг бидэнд зарлиг болгодог, мөн тэр биднийг чөлөөлөх болно.

14 Тиймийн тул, хайрт ах минь, Моронай, хилэнцтийн эсрэг сөрөн зогсоцгооё, мөн бид үгсээрээ сөрөн зогсож чадахгүй хилэнцэт болох юуг боловч, тийм ээ, бид эрх чөлөөгөө хадгалж болохын тулд, бид сүмийнхээ агуу боломжинд, мөн өөрсдийн Гэтэлгэгч бөгөөд Бурханыхаа хэрэгт баясаж болохын тулд зөрчил болоод тэмцлүүд гэх мэтийг илдээрээ “эсэргүүцэцгээе.

15 Тиймийн тул, эрчүүдээсээ цөөнийг нь авч надад яаралтай ир, мөн үлдсэнийг нь Лихай болон Тианкамын мэдэлд орхи; тэдэнд уг нутгийн тэр хэсэгт, түүнчлэн тэдэнд орших эрх чөлөөний төлөөх сэтгэл болох Бурханы “Сүнсний дагуу дайныг удирдах эрх мэдлийг тэдэнд өгөгтүн.

16 Болгоогтун та нарыг надад ирэх хүртэл тэд мөхөхгүй байж болохын тулд би тэдэнд цөөн хангамж илгээлээ.

17 Нааш ирэх замдаа чадахынхаа хэрээр хүчийг нэгтгэн цуглуул, мөн бидэнд буй итгэлийн дагуу Бурханыхаа хүчээр бид тэдгээр тэрслэгчдийн эсрэг хурдан явах болно.

18 Мөн бид Лихай Тианкам нарт илгээх илүү хоол хүнс олж болохын тулд, бид Зарахемлагийн хотыг эзэмшилдээ

авах болно; тийм ээ, бид Их Эзэний хүчээр тэдний эсрэг явах болно, мөн бид энэ агуу алдсыг төгсгөх болно.

19 Мөн эдүгээ, Моронай, би захидлыг чинь хүлээн авсандаа баясаж байна. Учир нь бид юу хийх талаар, ах дүүсийнхээ эсрэг явах нь бидний хувьд шударга эсэх талаар би бага зэрэг санаа зовж байлаа.

20 Гэвч тэд наманчлахгүй аваас чи тэдний эсрэг явахыг Их Эзэн чамд зарлигласныг чи хэлжээ.

21 Лихай Тианкам нарыг Их Эзэний хувьд чи “хүчирхэгжүүлэхээ мэдэгтүн; тэднийг, тийм ээ, мөн түүнчлэн тэдэнд Бурханы өгсөн тэрхүү эрх чөлөөнд бат зогссон тэд бүгдийг Бурхан чөлөөлөх учир бүү ай хэмээн тэдэнд хэл. Мөн эдүгээ хайрт ах, Моронайдаа зориулсан захидлаа би дуусгая.

БҮЛЭГ 62

Гидеоны нутаг дахь Пахоранд тусламж хүргэхээр Моронай жагсан одов—Улс орноо хамгаалахаас татгалзсан хааныг хүсэгч хүмүүс үхэлд хүргэгдэв—Пахоран Моронай хоёр Нифайхаг дахин авав—Аммоны хүмүүстэй олон леменчүүд нэгдэв—Аммороныг Тианкам алаад мөн өөрөө алагдав—Леменчүүд уг нутгаас гаргагдаж, мөн амар амгалан тогтоогдов—Хиламан тохиуулалдаа эргэн орж, Сүмийг

хөгжүүлэв. Ойролцоогоор мээ 62–57 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Моронай энэ захидлыг хүлээн аваад түүний зүрх зоригийг олон, мөн Пахоран эрх чөлөө хийгээд улс орныхоо талаас түүнчлэн “урвалгүй, үнэнч байсны учир, тэрээр үлэмж их баяслаар халгилан байв.

2 Гэвч тэрээр түүнчлэн Пахораныг шүүлтийн суудлаас зайлуулсан тэдний алдсын учир, тийм ээ, эцэст нь улс орныхоо мөн түүнчлэн Бурханыхаа эсрэг эсэргүүцсэн тэдний учир үлэмж харамсан гашуудав.

3 Мөнхүү улиран тохиох дор Пахораны хүслийн дагуу Моронай цөөн тооны эрсийг авч, мөн их цэргийнхээ үлдсэн хэсгийн удирдлагыг Лихай Тианкам нарт өгч, мөн Гидеоны нутгийн зүг жагсан одов.

4 Мөн тэрээр орсон газар болгондоо “эрх чөлөөний” далбаа босгож, мөн Гидеоны нутгийн зүг алхах зуураа чадах чинээгээрээ бүхий л хүчийг нэгтгэв.

5 Мөнхүү улиран тохиох дор мянга мянга нь түүний тугийн дор цуглаж, мөн тэд боолчлолд орохгүй байж болохын тулд, эрх чөлөөгөө хамгаалахаар илдээ агсацгаав.

6 Мөн тийн, Моронай жагсан явах бүхий л замдаа чадахын хэрээр бүх эрчүүдийг

нэгтгэн цуглуулаад, тэрээр Гидеоны нутагт ирэв; мөн өөрийн хүчийг Пахораны тэдэнтэй нэгтгээд тэд үлэмж хүчтэй болов, бүр “эрх чөлөөг хүсэгч хүмүүсийг Зарахемлагийн нутгаас гаргаж мөн уг нутгийг эзэмшилдээ авсан тэрслэгчдийн “хаан асан Пакусын хүмүүсээс ч илүү хүчтэй болов.

7 Мөнхүү улиран тохиох дор Моронай Пахоран нар их цэрэгтэйгээ Зарахемлагийн нутаг уруу очиж, мөн хотын эсрэг давшиж, мөн Пакусын хүмүүстэй тулгарч, үүнчлэн тэд тулалдахад хүрсэн ажгуу.

8 Мөн болгоогтун, Пакус алагдаж, мөн түүний хүмүүс олзлогдож, мөн Пахоран шүүлтийн суудалдаа сэргээгдэв.

9 Мөн Пакусын хүмүүс, мөн түүнчлэн баривчлагдсан мөн шоронд хаягдсан хааныг хүсэгч хүмүүс хуулийн дагуу шүүгдсэн бөлгөө; мөн тэд хуулийн дагуу “ялагдсан ажээ; тийм ээ, улс орноо хамгаалахаар зэвсэг агсахгүй, харин үүний эсрэг тулалдах гэсэн тэр болгон, Пакусын эдгээр хүмүүс мөн хааныг хүсэгч хүмүүс үхэлд хүргэгдэв.

10 Мөн улс орных нь аюулгүй байдлын тулд хууль хатуу чандаар мөрдөгдөх нь тийн зайлшгүй болов; тийм ээ, мөн эрх чөлөөгөө үгүйсгэж байгаа нь илчлэгдсэн хэн боловч хуулийн дагуу яаралтай ялагдаж байв.

11 Мөн ийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын гучдугаар он төгсөв; эрх чөлөөний хөдөлгөөнд үнэнч байгаагүй тэд бүгдийг үхлээр шийтгэж Моронай Пахоран нар Зарахемлагийн нутагт, өөрийн хүмүүсийн дунд, амар амгаланг сэргээв.

12 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын гучиннэгдүгээр оны эхэнд, Моронай тэр даруй хангамжуудыг илгээгдэхээр, мөн түүнчлэн зургаан мянган эрстэй их цэрэг Хиламанд, нутгийн тэр хэсгийг хадгалж үлдэхийн тулд түүнд туслуулахаар илгээгдэхээр болгов.

13 Мөн түүнчлэн тэрээр зургаан мянган эрстэй их цэрэг, хангалттай хэмжээний хүнстэйгээр, Лихай Тианкам нарын их цэрэг тийш илгээгдэхээр болгов. Мөнхүү улиран тохиох дор энэ нь леменчүүдийн эсрэг уг нутгийг бэхлэхээр хийгдсэн аж.

14 Мөнхүү улиран тохиох дор Моронай Пахоран нар хүмүүсийнхээ томоохон бүлгийг Зарахемлагийн нутагт орхиж, хүмүүсийнхээ томоохон бүлэгтэй хамт Нифайхагийн нутгийн зүг жагсан одов, тэд уг хот дахь леменчүүдийг дийлэхээр хатуу шийдсэний учир болой.

15 Мөнхүү улиран тохиох дор тэд уг нутгийн зүг жагсан явж байхдаа, тэд леменчүүдийн хүмүүсийн томоохон хэсгийг

баривчилж, мөн тэднээс олныг нь алж, мөн тэдний хангамжууд хийгээд дайны зэрэвсгүүдийг нь авав.

16 Мөнхүү улиран тохиох дор тэд тэднийг баривчилсныхаа дараа, тэд цаашид нифайчуудын эсрэг дайны зэрэвсгээ агсахгүй гэсэн гэрээнд тэднийг орох болгов.

17 Мөн тэднийг энэ гэрээнд орсны дараа, тэд Аммоны хүмүүстэй оршин суулгахаар тэднийг илгээж, мөн алагдаагүй тэд тоогоороо дөрвөн мянга орчим байв.

18 Мөнхүү улиран тохиох дор тэд тэднийг илгээгээд тэд Нифайхагийн нутгийн зүг жагсан явахаа үргэлжлүүлэв. Мөнхүү улиран тохиох дор тэд Нифайха хотод ирснийхээ дараа, тэд Нифайха хотын дэргэдэх тэр Нифайхагийн талд майхнуудаа босгосон болой.

19 Эдүгээ Моронай леменчүүдийг тэдний эсрэг тулалдахаар, уг талд гарч ирээсэй хэмээн хүсч байв; гэвч леменчүүд, тэдний үлэмж агуу зоригийг мэдэж байсан учир, мөн тэдний тооны ихийг болгоосон учир, тиймийн тул тэд тэдний эсрэг гарч ирж зүрхэлсэнгүй; тиймийн тул тэд тэр өдөр тулалдахаар ирсэнгүй.

20 Мөн шөнө болоход, Моронай шөнийн харанхуйд урагшлан, мөн хотын аль хэсэгт нь леменчүүд их цэрэгтэйгээ буудалласныг тагнахаар хэрмийн орой дээр гарав.

21 Мөнхүү улиран тохиох дор

тэд орцны дэргэд дорно хэсэгт нь байв; мөн тэд бүгд унтаж байв. Мөн эдүгээ Моронай их цэрэгтээ буцаж, мөн тэднийг хэрмийн орой дээрээс дотор тал уруу нь хэрмээс доош буулгаж болохын тулд бат бөх олснууд болон шатнуудыг яаравчлан бэлтгэх болгов.

22 Мөнхүү улиран тохиох дор Моронай өөрийн хүмүүсийг урагш давшин мөн хэрмийн орой дээр гарч, мөн леменчүүд их цэрэгтэйгээ буудаллаагүй хотын доторх тэр хэсэгт, тийм ээ, бүр баруун талд өөрсдийгөө буулгах болгов.

23 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгд, бат бөх олс мөн шатныхаа тусламжтайгаар шөнөөр хотод буулгагдаж; тийн өглөө болоход тэд бүгд хотын хэрмэн дотор байв.

24 Мөн эдүгээ, леменчүүд сэргэж мөн Моронайн их цэргийг хэрмэн дотор байгааг хараад, тэд үлэмж айцгааж, үүний хэрээр тэд гарцаар зугтаж гарав.

25 Мөн эдүгээ Моронай өөрийнх нь өмнө тэдний зугтаж буйг хараад, тэрээр өөрийн хүмүүсийг тэдний эсрэг урагш давшиж, мөн олныг нь алж мөн бусад олныг нь бүслэн, мөн тэднийг олзлогдогсод болгон баривчлах болгов; мөн тэдний үлдсэн нь тэнгисийн эргийн ойролцоох Моронайн нутаг тийш зугтав.

26 Ийн Моронай Пахоран нар Нифайха хотыг нэг ч

бодгалийн гарзгүйгээр эзэмшлээ олж авав; мөн леменчүүдээс алагдсан нь олон байв.

27 Эдүгээ улиран тохиох дор олзлогдсон леменчүүдээс олон нь Аммоны “хүмүүстэй нэгдэж, чөлөөт хүмүүс болох хүсэлтэй байв.

28 Мөнхүү улиран тохиох дор хүссэн болгонд, өөрсдийнх нь хүслийн дагуу байх нь тэдэнд зөвшөөрөгдсөн ажээ.

29 Тиймийн тул, леменчүүдийн бүх олзлогдогсад Аммоны хүмүүстэй нэгдэж, мөн газар боловсруулж, төрөл бүрийн үр тариа, мөн янз бүрийн бог болон бод мал өсгөж үлэмж хөдөлмөрлөж эхлэв; мөн ийн нифайчууд нэгэн их ачааллаас салав; тийм ээ, үүний хэрээр тэд леменчүүдийн бүх олзлогдогсдыг харгалзах хариуцлагаас ангижирсан ажгуу.

30 Эдүгээ улиран тохиох дор Моронай, Нифайха хотыг эзэмшилдээ авсныхаа дараа, леменчүүдийн их цэргийг үлэмж цөөрүүлэн, олныг олзолсныхоо дараа, мөн Моронайн их цэргийг үлэмж хүчирхэгжүүлсэн тэрхүү олзлогдсон нифайчуудаас олныг буцаан авсныхаа дараа; тиймийн тул Моронай Нифайхагийн нутгаас Лихайн нутаг тийш одов.

31 Мөнхүү улиран тохиох дор Моронай тэдний эсрэг ирэхийг леменчүүд хараад, тэд дахин айж мөн Моронайн их цэргийн өмнө зугтсан ажээ.

32 Мөнхүү улиран тохиох дор

Моронай болон түүний их цэрэг тэднийг хотоос хотод, тэднийг Лихай Тианкум нартай тулгарах хүртэл мөрдөн хөөв; мөн леменчүүд бүр тэнгисийн эргийн дэргэдэх хил хүртэл уруудан, тэд Моронайн нутагт ирэх хүртлээ Лихай Тианкум нараас зугтав.

33 Мөн леменчүүдийн их цэрэг бүгд нэгдэн цуглуулагдсан байв, үүний хэрээр тэд Моронайн нутагт бүгд нэг хэсэг байв. Эдүгээ Амморон, леменчүүдийн хаан, түүнчлэн тэдэнтэй хамт байлаа.

34 Мөнхүү улиран тохиох дор Моронай болон Лихай мөн Тианкум нар Моронайн нутгийн хилийн эргэн тойронд их цэрэгтэйгээ буудалласан байв, үүний хэрээр леменчүүд өмнөд аглаг буйдын хилийн, мөн дорнод аглаг буйдын хилийн дээр бүслэгдсэн байв.

35 Мөн тийн тэд шөнийг өнгөрөөхөөр буудаллав. Учир нь болгоогтун, нифайчууд мөн түүнчлэн леменчүүд аяныхаа агуу ихийн учир ядарсан байв; тиймийн тул тэд шөнийн цагт Тианкумаас бусад нь ямар нэгэн арга сэдсэнгүй; учир нь тэрээр Амморонд үлэмж ихээр уурлаж байв, учир юун гэвэл ийм их дайн мөн цус урсалт, тийм ээ, мөн ийм их өлсгөлөнгийн шалтгаан болсон тэдний болон леменчүүдийн хоорондох энэ агуу хийгээд үргэлжийн дайны “шалтгаан нь Амморон болон түүний ах

Амаликая нар хэмээн тэрээр эргэцүүлэн бодсон ажээ.

36 Мөнхүү улиран тохиох дор Тианкум уурандаа леменчүүдийн буудалд нэвтрэн орж, мөн хотын хэрэмнээс өөрийгөө буулгасан болой. Мөн тэрээр олстойгоо, газраас газарт явж, ингэснээр тэр хааныг олов; мөн тэрээр түүний зүг жад “шидэж, энэ нь түүний зүрхний ойролцоо зоогдов. Гэвч болгоогтун, хаан үхэхээсээ өмнө зарц нараа сэрээж, үүний хэрээр тэд Тианкумыг мөрдөж, мөн түүнийг алав.

37 Эдүгээ улиран тохиох дор Лихай Моронай хоёр Тианкум үхсэнийг мэдээд тэд үлэмж харамсаж байв; учир нь болгоогтун, тэрээр эх орныхоо төлөө эрэлхэгээр байлдсан хүн, тийм ээ, эрх чөлөөнд үнэнч нөхөр байсан ажгуу; мөн тэрээр үлэмж олон зовлонт зүдгүүрүүдийг тэвчсэн бөлгөө. Гэвч болгоогтун, тэрээр нас баржээ, мөн бүх хорвоогийн жамаар оджээ.

38 Эдүгээ улиран тохиох дор маргааш нь Моронай жагсан явж, мөн леменчүүдийн дээр ирж, үүний хэрээр тэднийг агуу их аллагаар тэд хөнөөв; мөн тэд уг нутгаас тэднийг гадагш түрэв; мөн тэд зугтаж, бүр тэд нифайчуудын эсрэг тэр үед дахин эргэж ирсэнгүй.

39 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын гучин нэгдүгээр он тийн төгсөв; мөн дайнууд, мөн цус

урсгалт, бас өлсгөлөн, бас зовлон олон жилийн турш тэдэнд тийн тохиов.

40 Мөн Нифайн хүмүүсийн дунд аллага, зөрчилдөөн, мөн тэрсэлдээн, мөн төрөл бүрийн алдсууд байв; гэсэн хэдий ч “зөв шударгыг үйлдэгчдийн төлөө, тийм ээ, зөв шударгыг үйлдэгчдийн залбирлын улмаас, тэд хэлтрүүлэгдсэн юм.

41 Гэвч болгоогтун, нифайчууд болон леменчүүдийн хоорондох дайны үлэмж агуу урт удааны учир олных нь зүрх сэтгэл хатуурчээ, уг дайны үлэмж агуу урт удааны учир бөлгөө; мөн олных нь зүрх сэтгэл “зүдгүүрүүдийнхээ учир зөөлөрч, үүний хэрээр тэд Бурханы өмнө өөрсдийгөө бүр даруу байдлын гүнд хүртэл даруусгасан ажээ.

42 Мөнхүү улиран тохиох дор уг нутгийн леменчүүдэд хамгийн ихээр өртөгдөж болох нутгийн тэдгээр хэсгийг хангалттай хүчирхэг болтол нь Моронай бэхэлсний дараагаар, тэрээр Зарахемла хотод эргэж иржээ; мөн түүнчлэн Хиламан өөрийн өв болох нутагтаа буцав; мөн Нифайн хүмүүсийн дунд дахин нэгэнтээ амар амгалан тогтоогдсон ажгуу.

43 Мөн Моронай их цэргийнхээ удирдлагыг, нэрийг нь Моронайха гэх хүүгийнхээ гарт өгөв; мөн тэрээр өөрийн үлдсэн өдрүүдээ амар амга-

ланд өнгөрөөж болохын тулд албаа дуусган гэртээ харив.

44 Мөн Пахоран шүүлтийн суудалдаа эргэж очсон болой; мөн Хиламан Бурханы үгийг хүмүүст номлох үүргийг өөртөө дахин авчээ; өөрөөр хэлбэл ийм олон дайн мөн зөрчилдөөнүүдийн улмаас сүмд дахин зохицуулалт хийх нь зайлшгүй болсон байв.

45 Тиймийн тулд, Хиламан мөн түүний ах дүүс одож, мөн Бурханы үгийг ихэд хүчтэйгээр тунхаглав, ингэснээр олон хүнд өөрсдийнх нь ёс бусын талаар “итгүүлэн, тиймээс тэднийг нүглүүдээ наманчилж мөн Их Эзэн Бурхандаа баптисм хүртэхэд хүргэв.

46 Мөнхүү улиран тохиох дор тэд бүх нутаг даяар Бурханы сүмийг дахин байгуулсан болой.

47 Тийм ээ, мөн хуулийн талаар зохицуулалтууд хийгдэв. Мөн тэдний “шүүгчид, мөн ерөнхий шүүгчид сонгогдов.

48 Мөн Нифайн хүмүүс нутагтаа дахин “дэгжиж эхлэв, мөн нутагтаа өнөржиж бас дахин үлэмж хүчирхэг болж эхлэв, мөн тэд үлэмж баян болж эхлэв.

49 Гэвч тэдний баялаг, өөрөөр хэлбэл хүч чадал, өөрөөр хэлбэл дэгжил хөгжил байсан хэдий ч, тэд өөрсдийнхөө нүдэнд бардамнан хөөрсөн нь үгүй; бас Их Эзэн Бурханаа дурсан санахдаа ч хойрго байсангүй; харин тэд

түүний өмнө өөрсдийгөө үлэмж даруусгасан ажээ.

50 Тийм ээ, Их Эзэн тэдний төлөө ямар агуу зүйлүүд хийснийг, тэрээр тэднийг үхлээс, мөн гав гинжнээс мөн шоронгоос, мөн төрөл бүрийн зүдгүүрүүдээс чөлөөлснийг, мөн тэрээр тэднийг дайснуудынх нь гараас чөлөөлснийг тэд санаж байв.

51 Мөн тэд Их Эзэн Бурхандаа үргэлж залбирч, үүний хэрээр Их Эзэн тэднийг өөрийн үгийн дагуу адисалсан бөлгөө, иймээс тэд хүчтэй болж мөн уг нутагт дэгжсэн юм.

52 Мөнхүү улиран тохиох дор эдгээр бүх зүйлүүд хийгдэв. Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын гучин тавдугаар онд Хиламан нас барав.

БҮЛЭГ 63

Шиблон мөн дараа нь Хиламан ариун цэдгүүдийг эзэмшилдээ авав—Олон нифайчууд умард нутаг тийш аялав—Хагот усан онгоц барьж, тэдгээр нь өрнөд тэнгист хөвөв—Моронайха тулалдаанд леменчүүдийг ялав. Ойролцоогоор мээ 56–52 он.

Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын гучин зургадугаар оны эхэнд, Алмагаар Хиламанд хүргэгдсэн “ариун зүйлүүдийг”⁶ Шиблон эзэмшилдээ авав.

2 Мөн тэр шударга хүн байв, мөн тэрээр Бурханы өмнө зөв шударгаар алхдаг байв; мөн тэр үргэлж сайныг үйлдэхийг, Их Эзэн Бурханыхаа зарлигуудыг дагахыг чармайдаг байв; мөн түүний дүү нь ч бас түүнчлэн буюу.

3 Мөнхүү улиран тохиох дор түүнчлэн Моронай нас барав. Мөн шүүгчдийн засаглалын гучин зургадугаар он ийн төгсөв.

4 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын гучин долдугаар онд, эрчүүдийн томоохон хэсэг, бүр таван мянга дөрвөн зуун эрс, эхнэр мөн хүүхдүүдийнхээ хамт, За-рахемла нутгаас гарч “умард дахь нутаг тийш одов.

5 Мөнхүү улиран тохиох дор Хагот, тэрээр үлэмж сониуч хүн байсан учир, тиймийн тул тэрээр одож мөн өөртөө үлэмж том усан онгоцыг, Өгөөмөр нутгийн хил дээр, Эзгүйрэл нутгийн захад барьж мөн өрнөд тэнгист, умард нутагт удирдах тэрхүү “нарийн хоолойн дэргэд усанд тавьжээ.

6 Мөн болгоогтун, үүнд сууж мөн их хүнс нөөцтэйгээр хөвж одсон нь нифайчуудаас олон байв, мөн түүнчлэн олон эмэгтэйчүүд мөн хүүхдүүд байв; мөн тэд умардыг чиглэн аянаа хөөв. Мөн гучин долдугаар он тийн төгсөв.

7 Мөн гучиннайм дахь онд энэ хүн өөр бусад онгоцуудыг

барив. Мөн эхний онгоц түүнчлэн эргэж ирэв, мөн өөр олон хүмүүс үүнд оров; мөн түүнчлэн тэд их нөөц хүнс авч мөн умард нутгийг дахин чиглэв.

8 Мөнхүү улиран тохиох дор тэднээс дахин сураг сонсогдсонгүй. Мөн бид тэднийг тэнгисийн гүнд живсэн буйза хэмээн бодном. Мөнхүү улиран тохиох дор өөр нэг онгоц түүнчлэн хөвж одов; мөн түүний хааш одсоныг бид мэдэх нь үгүй.

9 Мөнхүү улиран тохиох дор энэ онд “умард нутаг тийш одсон олон хүмүүс байв. Мөн гучин найм дахь он тийн төгсөв.

10 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын гучин есдүгээр онд, түүнчлэн Шиблон нас барж, мөн Кориантон тэр нутаг тийш одсон хүмүүст нөөц хүнс хүргэхээр умард нутаг тийш усан онгоцоор одсон бөлгөө.

11 Тиймийн тул нас бархынхаа өмнө, эцгийнхээ нэрээр нэрлэгдсэн, “Хиламаны хүүд, Хиламан гэж нэрлэгдсэн түүнд тэдгээр ариун нандин зүйлийг шилжүүлэх нь Шиблоны хувьд зайлшгүй болов.

12 Эдүгээ болгоогтун, Хиламаны эзэмшилд байсан тэдгээр бүх “сийлбэрүүд бичиглэгдэж мөн Алмагаар очих ёсгүй хэмээн зарлиг болгогдсон хэсгүүдээс бусад

4а Алма 22:31.
5а Алма 22:32;
Ифер 10:20.

9а Хил. 3:11–12.
11а Хиламаны номны
удиртгалыг үз.

12а Алма 18:36.
б Алма 37:27–32.

нь, бүх нутаг даяар хүмүүний үрсийн дунд илгээгдэв.

13 Гэсэн хэдий ч, эдгээр зүйлүүд нь ариун нандин хэвээр хадгалагдаж мөн нэг үеэс нөгөөд “доош гардуулагдах ёстой байв; тиймийн тул, энэ онд, тэдгээр нь Шиблоныг нас барахын өмнө Хиламанд шилжүүлэгдсэн байлаа.

14 Мөнхүү улиран тохиох дор түүнчлэн энэ онд леменчүүд дээр очсон зарим тэрслэгчид байв; мөн тэд нифайчуудын эсрэг уур уцаарт дахин өдөөн хатгагдав.

15 Мөн түүнчлэн мөнхүү онд тэд олон тооны цэрэгтэйгээр “Моронайхагийн хүмүүсийн эсрэг, өөрөөр хэлбэл Моронайхагийн их цэргийн эсрэг дайтахаар ирэв, ингэхдээ үлэмж их хохирол хүлээсээр, тэд ялагдан мөн нутгийнхаа зүг дахин ухарчээ.

16 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын гучин есдүгээр он тийн төгсөв.

17 Мөн Алмагийн, мөн түүний хүү Хиламаны, мөн түүнчлэн түүний хүү асан Шиблоны шастир ийн төгсөв.

ХИЛАМАНЫ НОМ

Нифайчуудын шастир оршвой. Тэдний дайн мөн зөрчил-дөөнүүд, мөн тэдний тэрсэлдээнүүд оршвой. Мөн түүнчлэн Хиламаны хүү асан Хиламаны цэдгүүдийн дагуу, мөн түүнчлэн түүний хөвгүүдийн цэдгүүдийн дагуу, Христийн ирэлтээс өмнөх үеэс, бүр Христийн ирэлтийг хүртэлх олон ариун бошиглогчдын бошиглалууд оршвой. Мөн түүнчлэн леменчүүдээс олон нь хөрвүүлэгдэв. Тэдний хөрвүүлгийн тухай шастир оршвой. Бүр Христийн ирэлтийг хүртэлх, Хиламаны ном хэмээн нэрлэгдсэн тэр Хиламан мөн түүний хөвгүүдийн цэдгийн дагуу леменчүүдийн зөв шударга явдал, нифайчуудын ёс бус хийгээд жигшүүрт хэргүүдийн тухай, мөн энэ мэтчилэнгийн шастир оршвой.

БҮЛЭГ 1

Хоёрдугаар Пахоран ерөнхий шүүгч болж мөн Кишкуменд алагдав—Пекүменаг шүүлтийн суудлыг эзлэв—Кориантумр леменчүүдийн их цэргийг удирдаж, Зарахемлаг аваад мөн

Пекүменаг алав—Моронайха леменчүүдийг ялж, Зарахемлаг буцаан авч, мөн Кориантумр алагдав. Ойролцоогоор мээ 52–50 он.

МӨН эдүгээ болгоогтун, Мулиран тохиох дор

Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын дөчдүгээр оны эхэнд, нифайчуудын ардын дунд ноцтой бэрхшээл эхлэв.

2 Учир нь болгоогтун, “Пахоран нас барж, мөн бүх хорвоогийн жамаар одов; тиймийн тул Пахораны хөвгүүд асан, ах дүүсийн дунд хэн шүүлтийн суудлыг эзэлбэл зохих талаар ноцтой зөрчилдөөн бий болж эхлэв.

3 Эдүгээ шүүлтийн суудлын төлөө тэмцэлдсэн мөн хүмүүсийг тэмцэлдэхэд хүргэсэн тэдний нэр нь эдгээр болой: Пахоран, Пейнкай болон Пекүменай.

4 Эдүгээ эдгээр нь Пахораны бүх хөвгүүд бус байв (учир нь түүнд олон байжээ), гэвч эд бол шүүлтийн суудлын төлөө тэмцэлдсэн тэд байв; тиймийн тул, тэд хүмүүсийн дунд гурван хэсгийг бий болгов.

5 Гэсэн хэдий ч, улиран тохиох дор Пахоран хүмүүсийн “саналаар Нифайн хүмүүсийн дээрх ерөнхий шүүгч мөн засаглагчаар томилогдов.

6 Мөнхүү улиран тохиох дор Пекүменай, тэрээр шүүлтийн суудлыг авч чадахгүйгээ хараад, тэрээр хүмүүсийн саналтай нэгдсэн ажээ.

7 Гэвч болгоогтун, Пейнкай болон түүнийг өөрсдийн захирагч болоосой хэмээх хүсэлтэй хүмүүсийн хэсэг нь үлэмж хилэгнэж байв; тиймийн тул, тэрээр ах дүүсийнхээ эсрэг тэдгээр хүмүүсийг

эсэргүүцэлд босгохоор зусардах гэж байв.

8 Мөнхүү улиран тохиох дор тэр үүнийг бараг л хийх гэж байхад, болгоогтун, тэр баривчлагдав, мөн хүмүүсийн саналын дагуу шүүгдэн, мөн үхлийн ял тулгагдсан аж; учир нь тэрээр эсэргүүцэлд босож мөн хүмүүсийн “чөлөөт байдлыг устгахыг эрэлхийлсэн ажээ.

9 Эдүгээ түүнийг өөрсдийн захирагч байхыг хүссэн тэдгээр хүмүүс тэрээр үхлийн ял хүлээхийг хараад, тиймийн тул тэд ууртай байв, мөн болгоогтун, тэд Кишкумен гэгч нэгнийг, бүр Пахораны шүүлтийн суудал уруу илгээж, мөн Пахораныг шүүлтийн суудал дээрээ сууж байхад нь түүнийг хөнөөв.

10 Мөн тэрээр Пахораны зарц нарт мөрдөн хөөгдөв; гэвч болгоогтун, Кишкумений зугталт ямар ч хүн түүнийг гүйцэж чадахааргүй тийм хурдан байжээ.

11 Мөн тэрээр өөрийг нь илгээсэн тэдэнд очив, мөн тэд Пахораныг Кишкумен алсныг хэнд ч хэлэхгүй хэмээцгээн өөрсдийн үүрдийн Бий Болгогчоороо тангараглан, тийм ээ, тэд бүгд гэрээнд оров.

12 Тиймийн тул, Кишкумен Нифайн хүмүүсийн дунд мэдэгдсэнгүй, учир нь тэрээр Пахораныг алах үедээ зүсээ хувиргасан байжээ. Мөн

Кишкумен болон түүнтэй гэрээ хийж үгсэн түүнтэй хуйвалдагсад, тэд бүгд олдох боломжгүй тийм байдлаар өөрсдөө хүмүүсийн дунд хутгалдав; гэвч олдсон бүгд нь “үхлээр яллагдав.

13 Мөн эдүгээ болгоогтун, хүмүүсийн дээрх захирагч бөгөөд ерөнхий шүүгч байхаар, ах Пахораныхоо оронд засаглахаар хүмүүсийн саналын дагуу Пекүменай тохоогдов; мөн энэ нь түүний эрхийн дагуу байв. Мөн энэ бүхэн шүүгчдийн засаглалын дөчдүгээр онд үйлдэгдэж; мөн тус он төгсгөл болов.

14 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын дөчин нэгдүгээр онд, леменчүүд тоолшгүй олон эрстэй их цэргийг нэгтгэн цуглуулж, мөн тэднийг сэлмээр, мөн илдээр мөн нум, мөн сумнууд, мөн толгойн дуулга, мөн цээжний хуягаар, мөн зүйл бүрийн бүх төрлийн хамгаалалтаар зэвсэглэсэн байв.

15 Мөн тэд нифайчуудын эсрэг дайн өдөөж болохын тулд дахин уруудаж ирэв. Мөн тэд Кориантумр гэдэг нэртэй эрээр удирдуулсан байв; мөн тэрбээр Зарахемлагийн удам байв; мөн тэрээр нифайчуудын дундаас тэрслэгч байв; тэрбээр том биетэй мөн чадалтай эр байв.

16 Тиймийн тул, “Аммораны хүү асан, нэрийг нь Тубалоф гэдэг байсан леменчүүдийн

хаан, Кориантумрыг чадалтай хүн байсан учраас нифайчуудын эсрэг өөрийн хүч чадал мөн түүнчлэн их мэргэн ухаанаараа зогсож чадна хэмээн, үүний хэрээр тэрээр түүнийг илгээснээрээ нифайчуудын дээр эрх мэдлийг олно хэмээн бодоод —

17 Тиймийн тул тэр тэднийг уурлуулахаар өдөөн хатгаж, мөн тэрээр их цэргээ нэгтгэн цуглуулж, мөн тэрээр Кориантумрыг тэдний удирдагч байхаар тохоож, мөн тэднийг Зарахемлагийн нутаг уруу нифайчуудын эсрэг байлдахаар давшин очих болгов.

18 Мөнхүү улиран тохиох дор засгийн газар дахь тийм их зөрчил мөн тийм их бэрхшээлийн учир, тэд Зарахемлагийн нутагт хангалттай харуулуудыг байлгасангүй; учир нь агуу их хот Зарахемлаг дайрахаар тэдний нутгуудын цээжинд леменчүүд ирж зүрхлэхгүй гэж тэд бодсон байв.

19 Гэвч улиран тохиох дор Кориантумр өөрийн олон тоотой цэргийнхээ тэргүүнд давшин алхаж байв, мөн уг хотын оршин суугчдын дээр ирэв, мөн тэдний алхах нь үлэмж хурдан байсан тул их цэргээ нэгтгэн цуглуулах цаг нифайчуудад байсангүй.

20 Тиймийн тул Кориантумр хотын хаалганы дэргэдэх харуулуудыг цавчиж, мөн бүх их цэрэгтэйгээ хотод давшин

орж, мөн тэд өөрсдийг нь эсэргүүцсэн хүн бүрийг хөнөөж, үүний хэрээр тэд бүхэл хотыг эзэмшилдээ авсан ажгуу.

21 Мөнхүү улиран тохиох дор ерөнхий шүүгч асан Пекүменай, Кориантумын өмнө, бүр хотын хэрмийг хүртэл зугтав. Мөнхүү улиран тохиох дор Кориантумр түүнийг ханатай хавсран цохиж, үүний хэрээр тэр үхэв. Мөн Пекүменайн өдрүүд тийн төгсөв.

22 Мөн эдүгээ Кориантумр Зарахемла хотыг эзэмшилдээ авснаа хараад мөн нифайчууд тэдний өмнө зугтаж, мөн алагдаж, мөн баривчлагдаж, мөн шоронд хаягдаж байсныг, мөн тэрээр бүх нутгийн хамгийн бат бөх хориглолтыг эзэмшилдээ олж авснаа хараад, түүний зүрх сэтгэл зоригжин үүний улмаас тэрээр бүх нутгийн эсрэг явах гэж байв.

23 Мөн эдүгээ тэрээр Зарахемлагийн нутагт үлдсэнгүй, харин тэрээр томоохон их цэргийн хамт, бүр Өгөөмөр хотыг чиглэн давшин алхсан болой; учир нь тэрээр уг нутгийн умард хэсгүүдийг эзлэн авч болохын тулд урагшлан явж мөн илдний хүчээр өмнөө зам гаргах нь түүний хатуу шийдвэр байв.

24 Мөнхүү, тэдний хамгийн их хүч нутгийн төвд байсан хэмээн бодоод, тиймийн тул тэдэнд жижиг хэсгүүдээс бусдаар бол нэгдэн цуглах цагийг өгөлгүйгээр тэр урагш давшив; мөн энэ маягаар тэд

тэдний дээр бууж мөн тэднийг газарт хиаруулан унагав.

25 Гэвч болгоогтун, алагдсан нифайчуудын тоо их олон байсан хэдий ч, уг нутгийн төв дундуурх Кориантумын энэ давшилт тэдний дээр агуу давуу байдалтай байх боломжийг Моронайхад өглөө.

26 Учир нь болгоогтун, леменчүүд уг нутгийн төвд орж ирж зүрхлэхгүй, харин тэд урьд нь тэгж байсныхаа адил хилийн ойролцоох хотуудад довтолно хэмээн Моронайха бодсон байв; тиймийн тул Моронайха хүчирхэг их цэргээ хилийн ойролцоох хэсгүүдийг хадгалан хамгаалуулахаар болгосон байлаа.

27 Гэвч болгоогтун, леменчүүд түүний хүслийн дагуу айсангүй, харин тэд уг нутгийн төвд орж ирэн, мөн нийслэл хот Зарахемла хотыг авав, мөн хүмүүсийг, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, мөн хүүхдүүдийг аль алиныг нь их аллагаар хөнөөсөөр, олон хот мөн олон хориглолтыг эзэмшилдээ авсаар уг нутгийн хамгийн гол чухал хэсгүүдийн дундуур давшин явж байлаа.

28 Гэвч Моронайха үүнийг олж мэдээд, тэднийг Өгөөмөр нутагт ирэхээс нь өмнө тэрээр Лихайг их цэргийн хамт тэднийг амдуулахаар тойруу замаар тэр даруй илгээв.

29 Мөн тэрээр тийн үйлдэв; мөн тэрээр тэднийг Өгөөмөр нутагт ирэхээс нь өмнө тэднийг амдан тосов, мөн

тэдэнтэй тулалдаж, үүний хэрээр тэд Зарахемлагийн нутгийн зүг гэдрэг ухарч эхлэв.

30 Мөнхүү улиран тохиох дор Моронайха тэдний ухралтад тэднийг амдаж, мөн тэдэнтэй тулалдаж, үүний хэрээр энэ нь үлэмжийн цуст тулаан болов; тийм ээ, олон нь алагдав, мөн алагдсан тэдний дунд “Кориантумр түүнчлэн байв.

31 Мөн эдүгээ, болгоогтун, леменчүүд хаашаа ч, умардад ч, бас өмнөдөд ч, бас дорнодод ч, бас өрнөдөд ч ухрах замгүй байв, учир нь тэд тал бүрээсээ нифайчуудаар бүслэгдэв.

32 Мөн тийн Кориантумр нифайчуудын дунд леменчүүдийг оруулсан байж, үүний хэрээр тэд нифайчуудын хүчинд автаж, мөн тэрээр өөрөө алагдав, мөн леменчүүд өөрсдийгөө нифайчуудын гарт өгчээ.

33 Мөнхүү улиран тохиох дор Зарахемла хотыг Моронайха эзэмшилдээ буцаан авч, мөн олзлогдогсод болгосон леменчүүдийг амар тайвнаар уг нутгаас гаргах болгов.

34 Мөн шүүгчдийн засаглалын дөчин нэгдүгээр он ийн төгсөв.

БҮЛЭГ 2

Хиламаны хүү асан тэрхүү Хиламан ерөнхий шүүгч болов— Кишкуменийн бүлэглэлийнхнийг Гадиантон удирдав— Хиламаны

зарц Кишкуменийг алж, мөн Гадиантоны бүлэглэл аглаг буйд тийш зугтав. Ойролцоогоор мээ 50–49 он.

Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын дөчин хоёрдугаар онд, нифайчууд болон леменчүүдийн хооронд Моронайха дахин амар амгаланг тогтоосны дараа, болгоогтун шүүлтийн суудлыг эзлэх хэн ч үгүй байв; тиймийн тул шүүлтийн суудлыг хэн эзэлбэл зохих талаар хүмүүсийн дунд дахин зөрчилдөөн гарч эхлэв.

2 Мөнхүү улиран тохиох дор Хиламаны хүү асан тэр Хиламан, хүмүүсийн саналаар, шүүлтийн суудлыг эзлэхээр тохоогдов.

3 Гэвч болгоогтун, Пахораныг алсан “Кишкумен, түүнчлэн Хиламаныг устгахаар отон хүлээсэн ажгуу; мөн тэр түүний ёс бусыг хэн ч мэдэхгүй хэмээх гэрээнд орсон бүлэглэлийнхнээрээ дэмжигдэв.

4 Учир нь, олон үг ярихдаа, мөн түүнчлэн аллагын болон дээрмийн нууц ажлыг удирдан явуулах башир аргадаа үлэмж мэргэшсэн “Гадиантон гэгч нэгэн байв; тиймийн тул тэрбээр Кишкуменийн бүлэглэлийн удирдагч болов.

5 Тиймийн тул хэрэв тэд өөрийг нь шүүлтийн суудалд суулгах аваас тэрээр бүлэглэлд нь харьяалагдсан тэд хүмүүсийн дунд хүч болон эрх мэдэл бүхий албанд

тохоогдохыг тэдэнд зөвшөөрнө хэмээн тэрээр тэднийг, мөн түүнчлэн Кишкуменийг зусардав; тиймийн тул Кишкумен Хиламаныг устгахыг эрэлхийлэв.

6 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Хиламаныг устгахаар шүүлтийн суудлын зүг урагшлан явах зуур, болгоогтун Хиламаны зарц нарын нэг нь, шөнөөр гадуур байж байгаад, мөн зүсээ хувиргаснаар, Хиламаныг устгахаар энэ бүлэглэлээр зохиогдсон төлөвлөгөөний тухай мэдэж авчээ —

7 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Кишкументэй тааралдахад, мөн тэрээр түүнд нэгэн нууц дохио өгч; тиймийн тул Кишкумен түүнд өөрийн хүсэл зорилгоо мэдүүлж, өөрөө Хиламаныг алж болохын тулд шүүлтийн суудлын зүг өөрийг нь дагуулахыг түүнээс хүсэв.

8 Мөн Кишкуменийн бүх зүрх сэтгэлийг, мөн алах нь хэрхэн түүний зорилго байгааг, мөн түүнчлэн алах, мөн дээрэмдэх, мөн хүчийг олох нь түүний бүлэглэлд харьяалагдсан тэд бүгдийн зорилт байсныг (мөн энэ нь тэдний “нууц төлөвлөгөө, мөн тэдний хуйвалдаан байв) Хиламаны зарц олж мэдээд, Хиламаны зарц Кишкуменд хэлэв: Шүүлтийн суудлын зүг явцгаая.

9 Эдүгээ энэ нь Кишкуменийг үлэмж баярлуулж, учир

нь тэрээр төлөвлөгөөгөө гүйцээнэ хэмээн бодсон болой; гэвч болгоогтун, тэд шүүлтийн суудлын зүг явж байх үед, Хиламаны зарц Кишкуменийг, бүр зүрхэнд нь хутгалав, иймээс тэрээр дуу гаргалгүйгээр үхэхийн унав. Мөн тэр гүйж мөн Хиламанд өөрийн бүх харсан, мөн сонсон, мөн хийсэн зүйлүүдээ хэлэв.

10 Мөнхүү улиран тохиох дор тэд хуулийн дагуу цаазлагдаж болохын тулд, дээрэмчид мөн нууц алуурчдын энэ бүлэглэлийнхнийг баривчлуулахаар Хиламан хүмүүсийг илгээв.

11 Гэвч болгоогтун, Кишкуменийн эргэж ирээгүйг Гадиантон олж мэдээд тэрээр устгагдах вий хэмээн айв; тиймийн тул тэрээр өөрийн бүлэглэлийнхнийг өөрийгөө дагах болгов. Мөн тэд уг нутгаас гарч, нууц замаар, аглаг буйд тийш зугтав; мөн Хиламан тийн тэднийг баривчлуулахаар хүмүүсийг илгээхэд тэд хаанаас ч олдсонгүй.

12 Мөн энэ Гадиантоны тухайд хожим илүү ихээр яригдах болно. Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын дөчин хоёр дахь он ийн төгсөв.

13 Мөн болгоогтун, энэ номын төгсгөлд энэхүү “Гадиантон Нифайн хүмүүсийн ялагдлыг, тийм ээ, бараг бүрэн устгалыг нь авчирсныг та нар харах болно.

14 Болгоогтун би Хиламаны номын төгсгөлийг бус, харин өөрийн бичиглэсэн тэр бүх шастираа би тэндээс авсан түүний буюу Нифайн номны төгсгөлийг хэлж байна.

БҮЛЭГ 3

Олон нифайчууд умард нутаг тийш нүүв—Тэд зуурмагаар байшингууд барьж мөн олон цэдэг хөтлөв—Хэдэн арван мянга нь хөрвүүлэгдэж мөн баптисм хүртэв—Бурханы үг хүмүүнийг авралд хүргэдэг—Хиламаны хүү Нифай шүүлтийн суудлыг эзлэв. Ойролцоогоор мээ 49–39 он.

Мөнхүү эдүгээ улиран тохиох дор дөчин гуравдугаар оны төгсгөлд хэргүүд нь шийдэгдсэн, зарим жижиг тэрслэлүүдийг хүмүүсийн дунд бий болгосон, бага зэрэг бардамнал сүмийн дотор байснаас бусдаар бол Нифайн хүмүүсийн дунд шүүгчдийн засаглалын дөчин гуравдугаар онд ямар ч зөрчилдөөн байсангүй.

2 Мөн дөчин дөрөвдүгээр онд хүмүүсийн дунд ямар ч зөрчилдөөн байсангүй; бас дөчин тавдугаар онд их зөрчилдөөн байсангүй.

3 Мөнхүү улиран тохиох дор дөчин зургадугаар онд, тийм ээ, их зөрчилдөөн мөн олон тэрслэл байв; үүний дүнд Зарахемла нутгаас гарч одоод, мөн “умард нутаг тийш уг

нутгийг өвлөхөөр явсан нь үлэмж олон байв.

4 Мөн тэд үлэмж агуу хол зайг аялан туулж, үүний хэрээр тэд “томхон нуурууд мөн олон голуудад тулж ирэв.

5 Тийм ээ, мөн уг нутгийн бүх хэсэгт, урьд нь уг нутгийг өвлөсөн олон оршин суугчдын учир модгүй мөн үржил шимгүй болгоогүй хэсгүүдэд тархан суурьшив.

6 Мөн эдүгээ ургаа модгүй л болохоос биш, уг нутгийн аль ч хэсэг нь үржил шимгүй байсангүй; гэвч урьд нь өвлөж байсан хүмүүсийн “устгалын агуу ихийн учир уг нутаг “үржил шимгүй хэмээгдэж байв.

7 Мөн уг нутгийн гадаргуу дээр зөвхөн багахан хэмжээний л ургаа мод үлдсэн учир, тиймийн тул нүүж ирсэн хүмүүс зуурмагаар ажиллахдаа үлэмж мэргэшив; тиймийн тул тэд дотор нь оршин суух зуурмаган байшингууд барив.

8 Мөнхүү улиран тохиох дор тэд өнөржиж мөн тархаж, мөн өмнөд нутгаас умард нутагт одож, мөн тархаж үүнийхээ хэрээр тэд бүхэл дэлхийн гадаргууг, “өмнөд тэнгисээс умард тэнгисийг хүртэл, өрнөд тэнгисээс дорнод тэнгисийг хүртэл бүрхэж эхлэв.

9 Мөн умард нутагт байсан хүмүүс майхнууд, мөн зуурмаган байшингуудад оршин суудаг байв, мөн тэд хойшид байшингуудаа, тийм ээ, хотуудаа, мөн ариун сүмүүдээ,

мөн синагогуудаа, мөн дугануудаа, мөн төрөл бүрийн барилгуудаа барих ургаа модтой байж болохын тулд тэд уг нутгийн гадаргуу дээр нахиалах мод бүрийг ургуулахаар болов.

10 Мөнхүү улиран тохиох дор умард нутагт ургаа мод үлэмж ховор байсны учир, тэд “усан онгоцоор ихийг илгээж байв.

11 Мөн тэд тийн тэднийг модоор бас зуурмагаар аль алинаар нь, олон хот барьж болохыг умард нутгийн хүмүүст боломжтой болгодог байв.

12 Мөнхүү улиран тохиох дор уг гарал нь лемен үндэстэн болох Аммоны “хүмүүсээс олон нь түүнчлэн тэр нутаг тийш оджээ.

13 Мөн энэ хүмүүсийн олноор нь, энэ хүмүүсийн хэрэг явдлын тухай, тэдний талаарх тодорхой мөн маш том олон цэдэг хөтлөгдөв.

14 Гэвч болгоогтун, леменчүүдийн мөн нифайчуудын, мөн тэдний дайнуудын, мөн зөрчилдөөнүүд, мөн тэрслэлүүд, мөн тэдний номлолууд, мөн тэдний бошиглолууд, мөн тэдний усан онгоцоор илгээдэг байсны нь, мөн тэдний усан онгоц барьдаг байсны нь, мөн тэдний “ариун сүмүүд мөн синагогууд мөн дугануудыг барьдаг байсны нь, мөн тэдний зөв шударга байдал, мөн тэдний ёс бус

байдал, мөн тэдний аллагууд, мөн тэдний дээрмүүд, мөн тэдний тонуулууд, мөн бүх төрлийн жигшүүрт хэргүүд мөн садар самуун явдлын талаарх шастир, тийм ээ, энэ хүмүүсийн хэрэг явдлуудын зууны нэг хэсэг нь ч үүнд агуулагдаж чадахгүй юм.

15 Гэвч болгоогтун, олон ном мөн төрөл бүрийн олон цэдэг буй, мөн тэдгээр нь ихэвчлэн нифайчуудаар хөтлөгдөж байв.

16 Мөн бүр тэд зөрчилд унасан мөн алагдан, дээрэмдүүлж, мөн мөрдөгдөн, мөн туугдаж, мөн хядагдан, мөн газрын гадаргуу дээр тараагдах хүртэл, мөн ёс бус, мөн зэрлэг, мөн хэрцгий болсон учир, тийм ээ, бүр леменчүүд болсон учир, хойшид нифайчууд хэмээн “нэрлэгдэхгүй болтлоо леменчүүдтэй хутгалдах хүртэл тэдгээр нь нэг үеэс нөгөөд нифайчуудаар гардуулагдсаар ирсэн бөлгөө.

17 Мөн эдүгээ би дахин өөрийн шастирт эргэн орёе; тиймийн тул, миний ярьсан нь Нифайн хүмүүсийн дундах агуу зөрчилдөөн, мөн саад бэрхшээлүүд, мөн дайнууд, мөн тэрслэлүүдийн дараа тохиосон байв.

18 Шүүгчдийн засаглалын дөчин зургадугаар он төгсөв;

19 Мөнхүү улиран тохиох дор уг нутагт, тийм ээ, бүр дөчин долдугаар онд, мөн түүнчлэн

10a Алма 63:5–8.

12a Алма 27:21–26.

14a 2 Ниф. 5:16;

Иаков 1:17;

3 Ниф. 11:1.

16a Алма 45:12–14.

б 1 Ниф. 5:16–19;

Алма 37:4.

дөчин наймдугаар онд агуу зөрчилдөөн байсаар байв.

20 Гэсэн хэдий ч Хиламан шударга ёс мөн тэгш эрхийг хүндэтгэн үзэж шүүлтийн суудлыг эзлэв; тийм ээ, тэрээр Бурханы тогтоолууд, мөн шүүлтүүд, мөн зарлигуудыг дагахыг хичээв; мөн тэрбээр Бурханы мэлмийд үргэлж зөвийг үйлдэж байв; мөн тэрбээр эцгийнхээ замуудаар алхсан юм, үүнийхээ хэрээр тэрээр уг нутагт дэгжив.

21 Мөнхүү улиран тохиох дор түүнд хоёр хөвгүүн төрсөн аж. Тэрбээр ахмадад нь “Нифайн нэрийг, мөн багад нь ⁶Лихайн нэрийг өгчээ. Мөн тэд Их Эзэний төлөө өсөж эхлэв.

22 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын дөчин наймдугаар оны төгсгөлд, нифайчуудын ардын дунд, дайнууд мөн зөрчилдөөнүүд бага зэргээр намдаж эхлэв.

23 Мөнхүү улиран тохиох дор уг нутгийн илүү хүн суурьшсан хэсгүүдэд дээрэмчин “Гадиантоны байгуулсан, нууц хуйвалдаанууд байснаас бусдаар бол шүүгчдийн засаглалын дөчин ес дэх онд уг нутагт үргэлжийн амар амгалан тогтоогдов, тэдгээр хуйвалдаанууд тэр үедээ засгийн газрын тэргүүнд байсан тэдэнд мэдэгдсэнгүй;

тиймийн тул тэд уг нутагт устгагдсангүй.

24 Мөнхүү улиран тохиох дор тэрхүү онд сүмд үлэмж агуу дэгжилт гарав, үүний хэрээр өөрсдөө сүмд нэгдэн мөн нанманчлалд хүргэгдэн баптисм хүртсэн нь мянга мянгаараа байв.

25 Мөн бүр дээд санваартнууд мөн багш нар өөрсдөө хэмжээлшгүй ихээр гайхан бахадсан сүмийн дэгжилт тийм агуу байж, мөн хүмүүсийн дээр юүлэгдсэн адислалууд тийм олон байв.

26 Мөнхүү улиран тохиох дор олон бодгаль, тийм ээ, бүр хэдэн арван мянга нь Бурханы сүмд баптисм хүртэж мөн нэгдсэнээр Их Эзэний ажил дэгжив.

27 Зүрх сэтгэлийнхээ гүнээс, түүний ариун нэрийг дуудах бүгдэд Их Эзэн нигүүлсэнгүй байдгийг бид ийн үзэж болох ажгуу.

28 Тийм ээ, “бүгдэд, бүр Бурханы Хүү болох Есүс Христийн нэрэнд итгэдэг тэдэнд, тэнгэрийн ⁶хаалга нээлттэйг бид тийн харлаа.

29 Тийм ээ, чөтгөрийн бүх башир аргыг мөн урхи мөн арга залиг нь тасчин хуваах, “амьд хүчирхэг, мөн ёс бусыг үйлдэгчдийг залгихаар бэлтгэгдсэн зовлонгийн үүрдийн ⁶ангал дээгүүр гарах давчуу бөгөөд ⁶нарийн замаар

21a су Нифай,
Хиламаны хүү.
б су Лихай,
Нифайчуудын
номлогч.

23a Хил. 2:4.
28a Үйлс 10:28;
Ром 2:10–11.
б 2 Ниф. 31:9, 17.
29a Евр. 4:12;

С ба Г 11:2.
б 1 Ниф. 15:28–30.
в 2 Ниф. 9:41; 33:9.

Христийн хүмүүнийг удирдах, Бурханы 'үгэн дээр тулгуурлахыг хүсэх хэн боловч тулгуурлаж —

30 Мөн тэнгэрийн хаант улсад, Бурханы "баруун мутар талд, Абрахамтай, мөн Исаактай, мөн Иаковтай хамт, мөн бидний бүх ариун эцэг өвгөдийн хамт, цаашид гарахгүйгээр суухаар өөрсдийн бодгалиудыг, тийм ээ, үхэшгүй бодгалиудаа байрлуулж болохыг бид харж болно.

31 Мөн тэрхүү онд Зарахемла нутагт, мөн эргэн тойрны бүх бүс нутгуудад, бүр нифайчуудаар эзэмшигдсэн бүх нутагт үргэлжийн баясал байв.

32 Мөнхүү улиран тохиох дор дөчин есдүгээр оны үлдсэн хугацаанд амар амгалан мөн үлэмж агуу баяр хөөр байв; тийм ээ, мөн шүүгчдийн засаглалын тавьдугаар онд түүнчлэн үргэлжийн амар амгалан мөн агуу баяр хөөр байв.

33 Мөн шүүгчдийн засаглалын тавин нэгдүгээр онд, сүмд нэвтэрч эхэлсэн — Бурханы сүмд бус, харин Бурханы сүмд харьяалагддаг хэмээх хүмүүсийн зүрх сэтгэлд орж эхэлсэн — бардамналаас бусдаар бол түүнчлэн амар амгалан байв.

34 Мөн тэд, бүр ах дүүсийнхээ олныг нь хавчин гадуур-

хах хүртлээ "бардамналдаа хөөрч байв. Эдүгээ энэ нь хүмүүсийн илүү даруухан хэсгийг их хавчлагыг тэсвэрлэхэд, мөн их зовлонгийн дундуур туулахад хүргэсэн тэрхүү агуу хилэнц байв.

35 Гэсэн хэдий ч сэтгэл оюун нь баясал хийгээд тайтгарлаар дүүрэх хүртлээ, тийм ээ, зүрх сэтгэлээ Бурханд "зориулсны учир ирэх ариуслаар зүрх сэтгэл нь бүр ^бариусаж мөн ^цэвэрших хүртлээ, тэд ойр ойрхон ^{ма}цаг барьж мөн ^дзалбирч, мөн ^едаруу байдалдаа улам улам хүчирхэг мөн Христийн бишрэлд улам улам гуйвшгүй бат болж байв.

36 Мөнхүү улиран тохиох дор тавин хоёр дахь он, мөн тэдний үлэмж их ^баялаг мөн уг нутаг дахь хөгжил дэгжлийн улмаас хүмүүсийн зүрх сэтгэлд нэвтэрсэн үлэмж агуу бардамналаас бусдаар бол түүнчлэн амар амгаланд төгсөв; мөн энэхүү бардамнал өдрөөс өдөрт тэдний дээр өсөн нэмэгдэж байв.

37 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын тавин гуравдугаар онд, Хиламан нас нөгчиж, мөн түүний ахмад хүү Нифай түүний оронд засаглаж эхлэв. Мөнхүү улиран тохиох дор тэрээр шударга ёс хийгээд тэгш эрхийг хүндэтгэж үзэн шүүлтийн суудлыг эзэлжээ; тийм ээ, тэрээр

29г су Бурханы Үг.
30а Мат. 25:33–34.
34а су Бардамнал.
35а Шаст. дэд 30:8;
Мозая 3:19.

б су Цэвэр ариун,
Цэвэр ариун байдал.
в су Ариусгал.
г су Мацаг барих,
Мацаг барилт.

д су Залбирал.
е су Даруу, Даруу
байдал.
36а су Баялгууд.

Бурханы зарлигуудыг дагаж, мөн эцгийнхээ замуудаар алхалсан болой.

БҮЛЭГ 4

Нифай үндэстний тэрслэгчид болон леменчүүд хүчээ нэгтгэж мөн Зарахемла нутгийг авав— Нифайчуудын ялагдлууд тэдний ёс бусынх нь улмаас ирэв— Сүм бууран доройтож, мөн хүмүүс леменчүүд шиг сул дорой болов. Ойролцоогоор мээ 38–30 он.

Мөнхүү улиран тохиох дор тавин дөрөвдүгээр онд сүмд олон тэрслэл байж, мөн түүнчлэн хүмүүсийн дунд “зөрчилдөөн байж, үүний хэрээр ихээхэн цус урсгалт байв.

2 Мөн эсэргүүцсэн хэсэг нь алагдаж мөн уг нутгаас туугдаж, мөн тэд леменчүүдийн хаанд очив.

3 Мөнхүү улиран тохиох дор тэд нифайчуудын эсрэг дайнд леменчүүдийг өдөөн хатгахаар чармайн оролдсон аж; гэвч болгоогтун, леменчүүд үлэмж айж, үүний хэрээр тэд тэрслэгчдийн үгсийг анхааран сонсохгүй байв.

4 Гэвч улиран тохиох дор шүүгчдийн засаглалын тавин зургадугаар онд, нифайчуудаас леменчүүдэд одсон “тэрслэгчид байв; мөн тэд бусадтайгаа тэднийг нифайчуудын эсрэг ууранд өдөөн хатгахад амжилт олов; мөн тэд тэрхүү оны турш дайнд бэлтгэжээ.

5 Мөн тавин долдугаар онд

тэд нифайчуудын эсрэг тулалдахаар ирж, мөн тэд үхлийн ажлыг эхэлсэн болой; тийм ээ, үүний хэрээр шүүгчдийн засаглалын тавин наймдугаар онд тэд Зарахемла нутгийг; тийм ээ, мөн түүнчлэн, бүр Өгөөмөр нутгийн дэргэд байсан нутгийг хүртэлх бүх нутгийг эзэмшилдээ авахад амжилт олов.

6 Мөн нифайчууд мөн Моронайхагийн их цэрэг бүр Өгөөмөр нутаг хүртэл туугдав;

7 Мөн леменчүүдийн эсрэг тэнд, өрнөд тэнгисээс, бүр дорнодыг хүртэл тэд бэхлэн суув; тэдний бэхэлсэн мөн умард нутгаа батлан хамгаалуулахаар их цэргээ байрлуулсан тэр хилийг дагах нь нифай үндэстэн хүний хувьд нэг өдрийн аян байв.

8 Мөн тийн нифайчуудын тэдгээр тэрслэгчид леменчүүдийн олон тоотой их цэргийн тусламжтайгаар өмнөд нутагт байсан нифайчуудын бүх эзэмшлийг олж авсан байв. Мөн энэ бүгд нь шүүгчдийн засаглалын тавин найм мөн тавин есдүгээр онуудад хийгдэв.

9 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын жардугаар онд, Моронайха их цэргийнхээ хамт уг нутгийн олон хэсгийг авахад амжилт олов; тийм ээ, тэд леменчүүдийн гарт орсон олон хотыг буцаан авсан ажгуу.

10 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын

жаран нэгдүгээр онд тэд бүх эзэмшлийнхээ бүр хагасыг нь буцаан авахад амжилт олов.

11 Эдүгээ тэдний дунд байсан, тийм ээ, мөн Бурханы сүмд харьяалагдах хэмээсэн тэдний дунд түүнчлэн байсан өөрсдийнх нь ёс бус, мөн жигшүүрт хэргүүд байгаагүй бол нифайчуудын энэ агуу алдагдал, мөн тэдний дунд байсан агуу аллага тохиохгүй байсан биз ээ.

12 Мөн тэдний зүрх сэтгэлийн “бардамналын учир, тэдний үлэмж “баялгийн нь учир, тийм ээ, тэд “ядууг дарамталж, өлссөнөөс хоолоо харамласан учир, нүцгэнээс хувцсаа харамласан учир, даруухан ах дүүсээ хацар дээр нь алгасан учир, ариун нандиныг элэг доог болгосон учир, бошиглолын болон илчлэлтийн суу билгийг үгүйсгэсэн учир, тэд аллага дээрэм, худал хуурмаг, хулгай, садар самууныг үйлдсэн учир, тэд агуу их зөрчилдөөнийг үүсгэсэн учир, мөн тэд зайлан одож, леменчүүдийн дунд Нифайн нутагт орсон учир—

13 Мөн тэдний энэ агуу ёс бусын учир, мөн тэд эрдэн хүчиндээ “барддагийн учир, тэд өөрсдийнхөө хүчинд орхигдов; тиймийн тул тэд дэгжсэнгүй, харин тэд нутгийнхаа бараг бүх эзэмшлийг алдах хүртлээ зовоогдож мөн цохигдож мөн леменчүүдийн өмнө туугдав.

14 Гэвч болгоогтун, тэдний алдсуудын учир Моронайха олон зүйлийг хүмүүст номлов, мөн түүнчлэн Хиламаны хөвгүүд, “Нифай, Лихай нар, хүмүүст олон зүйлийг номлож, тийм ээ, тэдний алдсуудын талаар мөн хэрэв тэд нүглүүдээ наманчлахгүй аваас тэдний дээр юу ирэх ёстой талаар олон зүйлийг бошиглосон болой.

15 Мөнхүү улиран тохиох дор тэд наманчилж, мөн тэд наманчилсныхаа хэрээр тэд дэгжиж эхлэв.

16 Өөрөөр хэлбэл Моронайха тэдний наманчилсныг хараад, тэрээр тэднийг нэг газраас нөгөө газарт, мөн хотоос хотод, бүр тэд хөрөнгийнхөө хагасыг мөн бүх нутгийнхаа хагасыг буцаан авах хүртэл удирдахаар зориглосон ажээ.

17 Мөн шүүгчдийн засаглалын жаран нэгдүгээр он тийн төгсөв.

18 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын жаран хоёрдугаар онд, Моронайха цаашид леменчүүдийг даван эзэмшлийг олж авч чадсангүй.

19 Тиймийн тул тэд нутгийнхаа үлдсэнийг нь олж авах гэсэн төлөвлөгөөгөө орхив, учир нь леменчүүд тийм олон тоотой байснаас, тэднийг давамгайлах илүү хүчийг олох нь нифайчуудын хувьд боломжгүй болов; тиймийн тул Моронайха өөрийн авсан

12a Обад. 1:3–4;
С ба Г 101:42.
б 1 Тим. 6:17;

2 Ниф. 9:42.
в С ба Г 42:30–31.
13a су Бардамнал.

14a Хил. 3:21.

хэсгүүдээ хадгалан хамгаалахад бүх их цэргээ дайчлав.

20 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн тооныг нь агуу ихийн учир дийлэгдэж, мөн дэвслэгдэн, мөн алагдан, мөн устгагдах болуузай хэмээн ихэд айсан байдалд нифайчууд байв.

21 Тийм ээ, тэд Алмагийн бошиглолууд, мөн түүнчлэн Мозаягийн үгсийг санаж эхлэв; мөн тэд зөрүүд хүмүүс байснаа, мөн тэд Бурханы зарлигуудыг үл ойшоосноо ухаарав;

22 Мөн тэд Мозаягийн “хуулиудыг өөрөөр хэлбэл хүмүүст өгөхийг Их Эзэн түүнд зарлигласан тэдгээрийг хөл доороо гишгэлснээ мөн өөрчилснөө; мөн тэд хуулиуд нь завхруулагдаж, мөн тэд ёс бус хүмүүс болж, үүний хэрээр тэд ёс бус, бүр леменчүүдийн адил байснаа тэд ухаарав.

23 Мөн тэдний алдсын учир сүм “бууран доройтож эхэлсэн байв; мөн тэд бошиглолын суу билэг, илчлэлтийн суу билэгт итгэхгүй болж эхлэв; мөн Бурханы шүүлтүүд нүүрэн дээр нь тулж иржээ.

24 Мөн тэд ах дүүсийнхээ, леменчүүдийн адил “сул дорой болсноо, мөн Их Эзэний Сүнс тэднийг цаашид хамгаалахаа больсныг ухаарав; тийм ээ, Их Эзэний ^бСүнс “ариун бус дугануудад үл оршихын

учир энэ нь тэднийг орхисон байв—

25 Тиймийн тул Их Эзэн тэднийг өөрийн гайхамшигт мөн зүйрлэшгүй хүчээр хамгаалахаа больж, учир нь тэд “итгэлгүй мөн аймшигт ёс бусын байдалд унасан байв; мөн тэднээс леменчүүд үлэмж илүү олон тоотой, мөн тэд Их Эзэн Бурхандаа ^бүнэнч байхгүй аваас тэд гарцаагүй мөхөх ёстойг тэд ойлгов.

26 Учир нь болгоогтун, леменчүүдийн хүч чадал тэдний хүч чадлын адил агуу, бүр нэг хүн нэгтэйгээ тэнцэхүйц байсныг тэд ойлгов. Мөн тэд энэ агуу зөрчилд тийн унасан байв; тийм ээ, тэд тийн зөрчлийнхөө учир “олон бус жилийн хугацаанд сул дорой болсон байв.

БҮЛЭГ 5

Нифай, Лихай нар өөрсдийгөө номлоход зориулав—Өөрсдийнх нь нэрс тэднийг өвөг дээдсийнхээ загвараар амьдрахад зоригжуулав—Христ наманчилдаг тэднийг гэтэлгэдэг—Нифай Лихай нар олныг хөрвүүлж мөн шоронд хаягдаж, мөн гал тэднийг хүрээлэв—Харанхуйн үүл гурван зуун хүмүүнийг сүүдэрлэв—Газар чичирч, мөн нэгэн дуу хоолой наманчлахыг хүмүүнд зарлиглав—Нифай Лихай хоёр тэнгэр элчүүдтэй ярьж, мөн

22a Алма 1:1.

23a су Урвалт.

24a Мозая 1:13.

б су Ариун Сүнс.

в Мозая 2:37;

Алма 7:21; 34:36.

25a су Итгэлгүй байдал.

б Иаков 6:5.

26a Алма 46:8;

Хил. 12:3–4.

цугларагсад галаар хүрээлэгдэв. Ойролцоогоор мээ 30 он.

Мөнхүү улиран тохиох дор тэрхүү онд, болгоогтун, “Нифай шүүлтийн суудлыг нэр нь Сизром гэдэг асан хүнд шилжүүлэв.

2 Учир нь тэдний хуулиуд хийгээд засгийн газар нь хүмүүсийн “саналаар тогтоогддог байв, мөн хилэнцтийг сонгосон тэд сайныг ^бсонгосон тэднээс илүү олон тоотой байсан учир, тиймийн тул тэд устгалдаа боловсорч гүйцээд байв, учир нь хуулиуд нь завхруулагдсан байжээ.

3 Тийм ээ, мөн энэ нь бүгд бус; тэд зөрүүд хүмүүс байв, үүний хэрээр устгал уруугаа бус аваас тэд хуулиар бас шударга ёсоор захирагдаж чадсангүй бөлгөө.

4 Мөнхүү улиран тохиох дор тэдний алдсын учир Нифай туйлдсан байв; мөн тэрбээр шүүлтийн суудлыг “өгч, мөн үлдсэн бүх өдрүүддээ мөн дүү Лихай нь ч түүнчлэн, өөрийн үлдсэн бүх өдрүүдэд Бурханы үгийг номлох үүргийг өөртөө хүлээн авав;

5 Учир нь тэд эцэг Хиламаныхаа тэдэнд ярьсан үгсийг санасан ажээ. Мөн түүний ярьсан үгс нь эдгээр болой:

6 Болгоогтун, хөвгүүд минь, та нар Бурханы зарлигуудыг дагахыг санаасай хэмээн хүснэ би; мөн та нар хүмүүст эдгээр үгсийг тунхаглаасай

хэмээнэ би. Болгоогтун, Иерусалимын нутгаас гарч ирсэн анхны “эцэг өвгөдийнхөө нэрсийг би та нарт өгсөн билээ; мөн та нар өөрсдийн нэрсийг санахдаа тэднийг санаж болно хэмээн би үүнийг хийсэн; мөн та нар тэднийг санахдаа та нар тэдний үйлүүдийг санаж болно; мөн та нар тэдний үйлүүдийг санахдаа тэдгээр нь ^бсайн байсан гэдэг нь хэлэгдэж, мөн түүнчлэн бичиглэгдсэнийг мэдэж болно.

7 Тиймийн тул, хөвгүүд минь, бүр тэдний тухай хэлэгдэж мөн бичигдсэн шиг, та нарын тухай хэлэгдэж, мөн түүнчлэн бичиглэгдэж болохын тулд, сайн болох түүнийг та нар үйлдээсэй хэмээнэ би.

8 Мөн эдүгээ хөвгүүд минь, болгоогтун би өөр заримыг та нараас хүсэх нь, та нар бардамнаж болохын тул эдгээр зүйлийг хийж болох бус, харин тийм ээ, та нар өөрсдөдөө мөнхийн болох тэрхүү, мөн онгож гандаад алга болох нь үгүй, тэрхүү эрдэнэсийг тэнгэрт “хураахаар эдгээр зүйлийг хийж болно; тийм ээ, бидний эцэг өвгөдөд өгөгдсөн хэмээн бодох шалтгаан бидэнд буй, мөнх амьдралын ^бэрхэм үнэт бэлэг та нарт байж болохыг эгээрэх тэрхүү хүсэл юм.

9 Ай санагтун, санагтун, хөвгүүд минь, хаан Бенжамин өөрийн хүмүүст ярьсан

5 1а Хил. 3:37.

2а Мозая 29:25-27.

б Алма 10:19.

4а Алма 4:15-20.

6а 1 Ниф. 1:1, 5.

б 2 Ниф. 33.

8а 3 Ниф. 13:19-21.

б С ба Г 14:7.

“үгсийг; тийм ээ, хүмүүн аврагдаж чадах өөр бусад зам ч, бас арга ч үгүй, зөвхөн ирэх, Есүс Христийн ^бцагаатгагч цусаар дамжин гэдгийг санагтун; тийм ээ, тэрээр энэ ^вдэлхийг ^ггэтэлгэхээр ирэхийг санагтун.

10 Мөн Аммонайха хотод, Зиезромд ярьсан Амюлекийн “үгсийг ч түүнчлэн санагтун; тодруулбал тэрбээр Их Эзэн өөрийн хүмүүсийг гэтэлгэхээр гарцаагүй ирэх болно, гэвч тэрээр тэднийг нүгэлд нь гэтэлгэхээр ирэх бус, харин тэднийг нүглүүдээс нь гэтэлгэхээр ирнэ хэмээн түүнд хэлсэн билээ.

11 Мөн наманчлалын учир нүглүүдээс нь тэднийг гэтэлгэхээр Эцэгээс түүнд хүч өгөгдсөн буй; тиймийн тул Гэтэлгэгчийн хүчинд, бодгалиудынх нь авралд хүргэх, наманчлалын нөхцөлүүдийн мэдээг тунхаглуулахаар тэрээр тэнгэр элчүүдээ “илгээсэн билээ.

12 Мөн эдүгээ, хөвгүүд минь, санагтун, Бурханы Хүү, Христ болох, бидний “Гэтэлгэгчийн хадан дээр та нар ^бсууриа тавих ёстойг санагтун; иймээс чөтгөр хүчит салхиа, тийм ээ, хуй салхин дахь дайралтаа илгээхэд, тийм ээ, түүний бүхий л мөндөр мөн хүчит

“шуурга та нар дээр нүдэхэд, энэ нь та нарыг зовлонгийн хийгээд төгсгөлгүй халагдалын ангал тийш доош чирж дийлэх хүчгүй байх болно, та нар дээр нь босгогдсон, бат бөх суурь дээр, хүмүүн нь үүний дээр баривал унах аргагүй суурь болох хадны учир болой.

13 Мөнхүү улиран тохиох дор хөвгүүддээ Хиламаны “заасан үгс нь эдгээр байсан болой; тийм ээ, тэрээр бичигдээгүй олон зүйлийг, мөн түүнчлэн бичигдсэн олон зүйлийг тэдэнд заажээ.

14 Мөн тэд түүний үгсийг санасан аж; мөн тиймийн тул тэд Бурханы зарлигуудыг даган, Бурханы үгийг Нифайн бүх хүмүүсийн дунд заахаар одож, Өгөөмөр хотоос эхлэв;

15 Мөн тэндээс цаашлан Гид хотод; мөн Гид хотоос Мюлек хотод;

16 Мөн бүр нэг хотоос нөгөөд, тэд өмнөд нутагт байсан Нифайн бүх хүмүүсийн дунд очих хүртлээ явж; мөн тэндээс Зарахемла нутагт, леменчүүдийн дунд очив.

17 Мөнхүү улиран тохиох дор тэд агуу хүчээр номлож, үүний хэрээр тэд нифайчуудыг орхин одсон “тэрслэгчдийн олныг нь шившиглэж, үүний хэрээр тэд ирж мөн

9а Мозая 2:9.

б Мозая 3:17–18.
сү Цагаатгах,
Цагаатгал.

в сү Дэлхий—
Зарлигуудыг
дуулгавартай
дагадаггүй хүмүүс.

г сү Гэтэлгэх,
Гэтэлгэгдэх,
Гэтэлгэл.

10а Алма 11:34.

11а Алма 13:24–25.

12а Мат. 7:24–27;

С ба Г 6:34;

Моисе 7:53.

сү Булангийн
тулгуур чулуу; Хад.
б Иса. 28:16;

Иаков 4:16.

в 3 Ниф. 14:25, 27.

13а Мозая 1:4.

17а Хил. 4:4.

нүглүүдээ хүлээн мөн наманчлалд хүргэгдэн баптисм хүртэж, мөн тэдний өмнө үйлдсэн буруугаа засахыг чармайн оролдохоор тэр даруй нифайчуудад эргэж ирэв.

18 Мөнхүү улиран тохиох дор Нифай Лихай нар леменчүүдэд тийм агуу хүч хийгээд эрх мэдэлтэйгээр номлож, учир нь тэд ярьж болохын тулд тэдэнд хүч мөн эрх мэдэл өгөгдсөн байв, мөн түүнчлэн тэдний “ярих ёстой зүйл тэдэнд өгөгдсөн байв —

19 Тиймийн тул тэд леменчүүдийн агуу гайхал бахдалыг төрүүлэн, тэднийг “итгэтэл нь ярив, үүний хэрээр Зарахемла мөн эргэн тойрны нутагт леменчүүдээс найман мянга нь наманчлалд хүргэгдэн баптисм хүртэж, мөн эцэг өвгөдийнхөө уламжлалын ёс бусад итгүүлэгдэв.

20 Мөнхүү улиран тохиох дор Нифай Лихай нар тэндээс Нифайн нутаг тийш аянаа үргэлжлүүлэв.

21 Мөнхүү улиран тохиох дор тэд леменчүүдийн их цэрэгт баривчлагдаж мөн “шоронд; тийм ээ, бүр Лимхайн зарц нараар Аммон болон түүний ах дүүсийн хаягдсан тэрхүү шоронд хаягдав.

22 Мөн тэд олон хоног шоронд хүнсгүйгээр хаягдсаны дараа, болгоогтун, тэд тэднийг алж болохын тулд тэднийг авахаар шоронд очив.

23 Мөнхүү улиран тохиох дор Нифай Лихай нар “галаар лугаа адил хүрээлэгдэж, бүр үүний хэрээр тэд түлэгдэх болов уу хэмээн айснаас тэдэнд гар хүрч зүрхэлсэнгүй. Гэсэн хэдий ч, Нифай Лихай нар түлэгдсэнгүй; мөн тэд галын дунд зогсох мэт боловч түлэгдсэнгүй.

24 Мөн тэд “галан баганаар хүрээлэгдсэнээ, мөн энэ нь өөрсдийг нь түлэхгүй байгааг хараад, тэдний зүрх сэтгэл зоригжив.

25 Учир нь тэд леменчүүд тэдэнд гар хүрч зүрхлэхгүй байгааг; бас тэдний дэргэд ирж зүрхлэхгүй байгааг, харин тэд гайхсандаа цочирдон балмагдсан мэт зогсохыг харав.

26 Мөнхүү улиран тохиох дор Нифай Лихай нар урагшлан зогсож мөн тэдэнд ярьж эхлэв, өгүүлсэн нь: Бүү ай, учир нь болгоогтун, энэ гайхамшигт зүйлийг та нарт үзүүлсэн нь Бурхан юм, үүнд та нар биднийг алахаар бидэнд гараа хүргэж чадахгүйг та нарт үзүүлж байна.

27 Мөн болгоогтун, тэд эдгээр үгсийг хэлэхэд газар үлэмж чичирч, мөн шоронгийн хананууд газарт нуран унах гэж байгаа мэтээр чичрэв; гэвч болгоогтун, тэдгээр нь унасангүй. Мөн болгоогтун, шорон дотор байсан тэд леменчүүд мөн тэрслэгчид болох нифайчууд байв.

18a С ба Г 100:5–8.
су Бошиглох,
Бошиглол.
19a су Хөрвүүлэг,

Хөрвөгч;
Номлолын ажил.
21a Мозая 7:6–7; 21:23.
23a Ег. 3:2.

24a Ег. 14:24;
1 Ниф. 1:6;
С ба Г 29:12;
ИС—Г 1:16.

28 Мөнхүү улиран тохиох дор тэд “харанхуйн үүлээр сүүдэрлэгдэж, мөн аймшигт цочирдом айдас тэдний дээр ирэв.

29 Мөнхүү улиран тохиох дор харанхуйн үүлний дээр байсан мэт “дуу хоолой ирж, өгүүлсэн нь: Наманчлагтун та нар, наманчлагтун та нар, мөн сайн мэдээг гунхаглуулахаар та нарт миний илгээсэн үйлчлэгчдийг минь устгахыг цаашид бүү эрэлхийлэгтүн.

30 Мөнхүү улиран тохиох дор тэд энэ дуу хоолойг дуулаад, мөн энэ нь аянгын дуу бус, бас агуу их хөл үймээний нүргээнт чимээ бус гэдгийг болгоож, гэвч болгоогтун, энэ нь шивнээн байсан мэт төгс зөөлөн “тайван дуу хоолой байж, мөн энэ нь сэтгэлийн угт хүртэл нэвтрэх ажгуу—

31 Мөн уг дуу хоолой зөөлөн байсан хэдий ч, болгоогтун газар үлэмж чичирч, мөн шоронгийн хананууд, газарт нурах гэж байгаа мэт дахин чичрэв; мөн болгоогтун тэднийг сүүдэрлэсэн, харанхуйн үүл сарнисангүй—

32 Мөн болгоогтун уг дуу хоолой дахин ирж, хэлсэн нь: Наманчлагтун та нар, наманчлагтун та нар, учир нь тэнгэрийн хаант улс ойрхон байна; мөн зарц нарыг минь устгахыг цаашид бүү эрэлхийлэгтүн. Мөнхүү улиран тохиох дор газар дахин чичирч, мөн хананууд доргилоо.

33 Мөн түүнчлэн дахин гурав дахь удаагаа дуу хоолой

ирж, мөн хүмүүнээр хэлэгдэх аргагүй гайхамшигт үгсийг тэдэнд ярьсан болой; мөн хананууд дахин доргиж, мөн газар хэдэн хэсэг хуваагдах гэж байгаа мэт чичрэв.

34 Мөнхүү улиран тохиох дор тэднийг сүүдэрлэх харанхуйн үүлсийн учир леменчүүд зугтаж чадсангүй; тийм ээ, мөн түүнчлэн тэдний дээр ирсэн айдсын учир хөдөлгөөнгүй байв.

35 Эдүгээ тэдний дунд нэгэнтээ Бурханы сүмд харьяалагдаж асан, гэвч тэднээс тэрсэлсэн уг гарал нь нифай үндэстэн болох нэгэн байв.

36 Мөнхүү улиран тохиох дор тэрээр эргэж, мөн болгоогтун, тэрээр харанхуйн үүлэн дундаас Нифай, Лихай хоёрын царайг харав; мөн болгоогтун, бүр тэнгэр элчүүдийн царай мэт, тэднийх ч үлэмж “туяарч байв. Мөн тэд мэлмийгээ тэнгэрт хандуулан өргөснийг тэрээр болгоов; мөн тэд өөрсдийн болгоох ямар нэгэн биетэй дуугаа өргөн өөрөөр хэлбэл ярьж буй маягтай байв.

37 Мөнхүү улиран тохиох дор энэ хүн, тэд эргэж мөн харж болохын тулд цугласан олны зүг хашгирав. Мөн болгоогтун, тэд эргэж мөн харах хүч тэдэнд өгөгдөв; мөн тэд Нифай Лихай хоёрын царайг болгоов.

38 Мөн тэд уг хүнд хэлэв: Болгоогтун, эдгээр бүх зүйл ямар утгатайв, мөн эдгээр

эрстэй ярилцах тэр нь хэн билээ?

39 Эдүгээ уг хүний нэр Аминадаб байв. Мөн Аминадаб тэдэнд хэлэв: Тэд Бурханы тэнгэр элчүүдтэй ярилцаж байна.

40 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд түүнд хэлэв: Энэ харанхуйн үүл биднийг сүүдэрлэхээ больж, нүүхийн тулд бид “юу хийх билээ?”

41 Мөн Аминадаб тэдэнд хэлэв: Та нар “наманчилж, бүр Алмагаар, мөн Амюлек хийгээд Зиезромоор та нарт тухайлан сургагдсан тэрхүү Христэд ⁶итгэлтэй болох хүртлээ уг дуу хоолойноос гуйх ёстой; мөн та нар үүнийг хийхэд, харанхуйн үүл та нарыг сүүдэрлэхээ больж нүүх болно.

42 Мөнхүү улиран тохиох дор газрыг чичиргэж асан түүний дуу хоолойнд тэд бүгд залбиран гуйж эхлэв; тийм ээ, тэд бүр харанхуйн үүлс сарних хүртэл гуйв.

43 Мөнхүү улиран тохиох дор тэд нүд гүйлгэн хараад, мөн харанхуйн үүл тэднийг сүүдэрлэхээ болино сарнисныг үзээд, болгоогтун, тийм ээ, бодгаль болгон галан баганаар “хүрээлэгдсэн байснаа тэд үзэв.

44 Мөн Нифай, Лихай хоёр тэдний дунд байв; тийм ээ, тэд хүрээлэгдэв; тийм ээ, тэд дүрэлзэх галын дунд буй мэт

байв, гэсэн ч энэ нь тэднийг гэмтээсэнгүй, бас шоронгийн ханыг шатаасангүй; мөн тэд алдар суугаар дүүрэн мөн үгээр хэлэхийн аргагүй “баяс-лаар дүүргэгдэв.

45 Мөн болгоогтун, Бурханы “Ариун Сүнс тэнгэрээс доош ирж, мөн тэдний зүрх сэтгэлийг эзэмдэв, мөн тэд дүүргэгдсэн лугаа адил болж, мөн тэд гайхамшигт үгсийг ⁶арьж чадав.

46 Мөнхүү улиран тохиох дор нэгэн дуу хоолой тэдэнд ирж, тийм ээ, шивнээн лугаа адил тааламжит дуу хоолой өгүүлсэн нь:

47 “Амар амгалан, амар амгалан та нарт байг, дэлхийн үүслээс байсан Ихэд Хайрлагдсанд минь итгэсэн та нарын итгэлийн учир бөлгөө.

48 Мөн эдүгээ, тэд үүнийг сонсоод сайхь дуу хоолой хаанаас ирснийг болгоох гэсэн мэт нүдээ өргөв; мөн болгоогтун, тэд “тэнгэр нээгдэхийг үзэв; мөн тэнгэрээс тэнгэр элчүүд бууж ирээд мөн тэдэнд тохинуулав.

49 Мөн эдгээр зүйлийг харж мөн сонссон гурван зуу орчим бодгаль байв; мөн тэд одож мөн эс гайхаж, бас үл эргэлзсэн нь тушаагдав.

50 Мөнхүү улиран тохиох дор тэд одож, мөн эргэн тойрны бүх бүс нутаг даяар өөрсдийн сонссон мөн үзсэн бүх зүйлийг тунхагласаар, хүмүүст

40a Үйлс 2:37–39.

41a су Наманчлах,
Наманчлал.

6 су Итгэл.

43a 3 Ниф. 17:24; 19:14.

44a су Баяр баясгалан.

45a 3 Ниф. 9:20;

Ифер 12:14.

6 су Сүнсний

бэлгүүд.

47a су Амар амгалан.

48a 1 Ниф. 1:8.

тохинуулж, үүний хэрээр леменчүүдийн ихэнх хэсэг, өөрсдийнхөө хүлээж авсан нотолгоонуудын агуу ихийн учир тэднээр итгүүлэгдэв.

51 Мөн “итгүүлэгдсэн болгон нь дайны зэр зэвсгүүдээ, мөн түүнчлэн эцэг өвгөдийнхөө үзэн ядалт хийгээд уламжлалыг орхив.

52 Мөнхүү улиран тохиох дор эзэмшлийнх нь нутгуудыг нифайчуудад тэд өгөв.

БҮЛЭГ 6

Зөв шударга леменчүүд, ёс бус нифайчуудад номлов—Хүмүүсийн аль аль нь нэгэн эриний турш амар амгалан хийгээд хангалуун байдалд дэгжив—Люсифер, нүглийн үүсгэгч ёс бусыг үйлдэгчдийн мөн Гадиянтоны дээрэмчдийн зүрх сэтгэлийг аллага хийгээд ёс бус үйлд өдөөн хатгав—Дээрэмчид нифай үндэстний засгийн газрыг дайран эзлэв. Ойролцоогоор мэв 29–23 он.

Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын жаран хоёрдугаар он төгсөхөд, эдгээр бүх зүйл тохиосон байв мөн леменчүүд, тэдний ихэнх хэсэг нь, зөв шударга хүмүүс болцгоосон байлаа, үүний хэрээр тэдний “зөв шударга нь, тэдний итгэл дэх чанд байдал хийгээд гуйвшгүй чанарын учир нифайчуудынхаас илүү болсон байв.

2 Учир нь болгоогтун, нифайчуудаас “хатуурхдаг мөн үл наманчилдаг мөн бузар ёс бус болсон нь олон байв, үүний хэрээр Бурханы үгийг мөн тэдний дунд ирсэн бүх номлолыг мөн бошиглолыг тэд эсэргүүцсэн ажгуу.

3 Гэсэн хэдий ч, сүмийн хүмүүс леменчүүдийн хөрвүүлгийн учир, тийм ээ, тэдний дунд байгуулагдсан Бурханы сүмийн учир агуу баяртай байв. Мөн тэд нэг нэгэнтэйгээ “дотнотсон нөхөрлөж, мөн нэг нэгэндээ баясан, мөн агуу баяртай байв.

4 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдээс олон нь Зарахемла нутаг уруу ирж, мөн нифайчуудын ард түмэнд өөрсдийн “хөрвүүлгийн маягийг тунхаглаж, мөн тэднийг итгэлд хийгээд наманчлалд ухуулав.

5 Тийм ээ, олон нь үлэмж агуу хүч чадал мөн эрх мэдлээр номлосноос, тэдний олныг нь, Хурганы мөн Бурханы даруу дагалдагчид байхаар даруу байдлын гүнд хүргэн доош авчрав.

6 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн олон нь умард нутаг тийш одов; мөн түүнчлэн Нифай Лихай хоёр “умард нутаг тийш хүмүүст номлохоор одов. Мөн жаран гуравдугаар он тийн төгсөв.

7 Мөн болгоогтун, бүх нутагт амар амгалан байж, үүний хэрээр нифайчуудын

51a Алма 31:5.
6 1a Хил. 13:1.
2a Ром 1:28–32.

3a су Нөхөрлөл.
4a су Хөрвүүлэг,
Хөрвөгч.

6a Алма 63:4–9;
Хил. 3:11–12.

эсвээс леменчүүдийн дунд гэдгээс үл хамааран нифайчууд уг нутгийн хүссэн хэсэгтээ очиж байв.

8 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд ч түүнчлэн леменчүүдийн дунд эсвээс нифайчуудын дунд гэдгээс үл хамааран хүссэн зүгтээ хаа хамаагүй явж байв; мөн тэд тийн хүслийнхээ дагуу, худалдан авч мөн худалдаж, мөн орлого олж нэг нэгэнтэйгээ чөлөөтэй харьцаж байв.

9 Мөнхүү улиран тохиох дор тэд, леменчүүд мөн нифайчуудын аль аль нь үлэмж баян болов; мөн үлэмж хангалттай алт, мөн мөнгө, мөн бүх төрлийн үнэт төмөрлөг, өмнөд нутагт мөн умард нутагт аль алинд нь тэдэнд байв.

10 Эдүгээ өмнөд нутаг нь Лихай гэж, мөн умард нутаг Зедикаягийн хүүгийн нэрээр “Мюлек гэж нэрлэгдэв; учир нь Их Эзэн Мюлекийг умард нутагт, мөн Лихайг өмнөд нутагт авчирсан ажээ.

11 Мөн болгоогтун, эдгээр нутагт аль алинд нь зүйл бүрийн алт, мөн мөнгө, мөн төрөл бүрийн үнэт хүдэр байв; мөн бүхий л төрлийн хүдрийг боловсруулж мөн үүнийг цэвэршүүлэх уран дархан ч түүнчлэн байв; мөн тэд тийн баян болсон ажгуу.

12 Тэд умард болон өмнөдөд аль алинд нь, үр тариаг элбэгээр ургуулсан болой; мөн умард болон өмнөдөд аль алинд нь тэд үлэмж цэцэглэн

хөгжив. Мөн тэд өнөржиж мөн уг нутагт үлэмж хүчтэй болов. Мөн тэд олон бог мал, мөн бод мал, тийм ээ, олон төл мал өсгөсөн болой.

13 Болгоогтун эмэгтэйчүүд нь нөр хичээнгүй хөдөлмөрлөж мөн утас ээрч, мөн бүхий л төрлийн даавуу, нарийн нэхээст эд мөн даавууны төрөл бүрийг нүцгэн биесээ хувцаслахаар хийв. Мөн жаран дөрөв дэх он амар амгаланд тийн улирч одов.

14 Мөн жаран тав дахь онд түүнчлэн агуу баясал мөн амар амгалан, тийм ээ, ирэх зүйлийн талаар их номлол мөн олон бошиглол тэдэнд байв. Мөн жаран тав дахь он тийн улирч одов.

15 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын жаранзургадугаар онд, болгоогтун, “Сизром шүүлтийн суудалд сууж байх үед, тэрээр үл мэдэгдэх гарт өртөж алагдав. Мөнхүү улиран тохиох дор тэрхүү онд, түүний хүү, хүмүүсээр түүний оронд тохоогдсон тэр нь, түүнчлэн алагдав. Мөн жаран зургадугаар он тийн төгсөв.

16 Мөн жаран долдугаар оны эхэнд хүмүүс дахин үлэмж ёс бус болж эхлэв.

17 Учир нь болгоогтун, Их Эзэн тэднийг дэлхийн баялгуудаар урт удаан хугацаанд адисалсан учир тэд уурлахаар, дайтахаар, бас цус урсгахаар өдөөгдөөгүй байжээ; тиймийн тул тэд зүрх

сэтгэлээ баялгууд дээрээ тавьж эхлэв; тийм ээ, тэд нэг нь нөгөөгийнхөө дээр гарч болохын тулд тэд хөрөнгөжихийг эрэлхийлж эхлэв; тиймийн тул тэд хөрөнгөжиж болохын тулд тэд “нууц аллагууд үйлдэж, мөн дээрэмдэж мөн тонож эхлэв.

18 Мөн эдүгээ болгоогтун, тэдгээр алуурчид хийгээд тонуулчид Кишкумен болон “Гадиантоноор байгуулагдсан нэгэн бүлэглэл болов. Мөн эдүгээ улиран тохиох дор Гадиантоны бүлэглэлээс олон нь, бүр нифайчуудын дунд байв. Гэвч болгоогтун, леменчүүдийн илүү ёс бус хэсгийн дунд тэд илүү олон тоотой байв. Мөн тэд Гадиантоны дээрэмчид, алуурчид хэмээн нэрлэгдэв.

19 Мөн ерөнхий шүүгч Сизром, мөн түүний хүүг, шүүлтийн суудалд байхад алсан нь тэд байв; мөн болгоогтун, тэд олж илрүүлэгдээгүй ажээ.

20 Мөн эдүгээ улиран тохиох дор тэдний дунд дээрэмчид байсныг олж мэдээд леменчүүд үлэмж харамсав, мөн тэднийг газрын гадаргуу дээрээс арилган устгаж болохын тул тэд хүч хүрэх арга бүрийг хэрэглэв.

21 Гэвч болгоогтун, нифайчуудын ихэнх хэсгийнх нь зүрх сэтгэлийг Сатан өдөөж, үүний хэрээр тэд дээрэмчдийн бүлэглэлтэй нэгдэж,

мөн тэд нэг нэгнээ ямар ч хэцүү нөхцөл байдалд орсон байсан, тэд аллагууд, мөн тонуулууд мөн хулгайнуудынхаа төлөө шийтгэгдэхгүйн тулд тэднийг хаацайлан мөн хамгаална хэмээн тэднийг гэрээ болон тангарагт нь оров.

22 Мөнхүү улиран тохиох дор тэд дохионууд, тийм ээ, “нууц дохионууд, мөн нууц үгстэй байв; тэд гэрээнд орсон ах дүүсээ ялгаж болохын тулд эдгээр нь байв, тиймээс ах дүүс нь ямар ч ёс бусыг үйлдсэн, ах дүүсээрээ, бас энэхүү гэрээг авсан түүний бүлэглэлд харьяалагдах тэднээр гэмтээгдэхгүйн тулд буюу.

23 Мөн тэгснээр улс орныхоо хуулиудын мөн түүнчлэн Бурханыхаа хуулиудын эсрэг, тэд алж, мөн тонож, мөн хулгайлж, мөн садар самуун мөн бүхий л төрлийн ёс бусыг үйлдэх боломжтой болсон ажгуу.

24 Мөн тэдний бүлэглэлд харьяалагдсан тэднээс “ёс бус мөн жигшүүрт хэргүүдийнхээ талаар дэлхийд илчлэх хэн боловч, улсынхаа хуулиудын дагуу бус, харин Гадиантон болон Кишкуменээр өгөгдсөн, өөрсдийн ёс бус хуулиудын дагуу шүүгдэх болно.

25 Эдүгээ болгоогтун, тэд хүмүүсийг доош устгалд авчрах хэрэгсэл болуузай хэмээн айж, дэлхийд одох хэрэггүй

хэмээн Алма хүүдээ зарлигласан нууц “тангаргууд мөн гэрээнүүд нь эдгээр бөлгөө.

26 Эдүгээ болгоогтун, тэдгээр “нууц тангаргууд мөн гэрээнүүд нь Хиламанд хүргэгдсэн цэдгүүдээс Гадиантонд ирээгүй; гэвч болгоогтун, тэдгээр нь бидний анхны эцэг эхийг хориглогдсон жимснээс хүртэхэд уруу татсан тэрхүү ^бнэгэн биеэр Гадиантоны зүрх сэтгэлд мэдүүлэгдсэн бөлгөө —

27 Тийм ээ, хэрэв тэрбээр дүү Абелаа алах аваас энэ нь дэлхийд мэдэгдэхгүй хэмээн “Каинтай хуйвалдсан тэрхүү бие билээ. Мөн тэр цагаас хойш тэрбээр Каин болон түүний дагалдагсадтай хуйвалдсаар ирсэн билээ.

28 Мөн тэд тэнгэрт хүрч болох хангалттай өндөр цамхаг “барих бодлыг хүмүүсийн зүрх сэтгэлд төрүүлсэн нь түүнчлэн тэрхүү бие бөлгөө. Мөн уг цамхагас энэ нутагт ирсэн тэр хүмүүсийг удирдсан нь; хүмүүсийг ^ббүрмөсөн сүйрэх устгалд, мөн үүрдийн тамд чирэн оруултал харанхуйн ажлыг мөн жигшүүрт хэргүүдийг бүх нутгийн гадаргуугаар нэг тараасан нь тэрхүү бие билээ.

29 Тийм ээ, харанхуйн мөн нууц аллагын ажлыг үргэлжлүүлсээр байх бодлыг “Гадиантоны зүрх сэтгэлд

төрүүлсэн нь тэрхүү бие; мөн тэрээр энэ ажлыг хүмүүний эхлэлээс бүр энэ цагийг хүртэл авчирсан юм.

30 Мөн болгоогтун, бүх нүглийг “үүсгэгч нь тэр болой. Мөн болгоогтун, хүмүүний үрсийн зүрх сэтгэлд нөлөө олж чадсныхаа хэрээр тэрбээр өөрийн харанхуйн мөн нууц аллагын ажлыг үргэлжлүүлж, мөн тэдний хуйвалдаанууд, мөн тангаргууд, мөн гэрээнүүд, мөн аймшигт ёс бус төлөвлөгөөнүүдийг нь үеэс үед гардуулан өгдөг.

31 Мөн эдүгээ болгоогтун, нифайчуудын зүрх сэтгэлд агуу нөлөөг олж; тийм ээ, үүний хэрээр тэд үлэмж ёс бус болсон байв; тийм ээ, тэдний ихэнх хэсэг нь зөв шударга замыг орхисон байв, мөн Бурханы зарлигуудыг “хөл дороо дэвсэлж, мөн өөрсдийн замуудыг хөөж, мөн алт болон мөнгөөрөө өөрсөддөө шүтээнүүдийг босгосон ажээ.

32 Мөнхүү улиран тохиох дор “цөөн жилийн хугацаанд тэдний дээр эдгээр бүх алдсууд ирж, үүний хэрээр Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын жаран долдугаар онд эдгээрийн ихэнх хэсэг нь тэдний дээр ирсэн байв.

33 Мөн жаран найм дахь онд ч түүнчлэн, зөв шударгыг үйлдэгсдийн агуу харамсал

25a Алма 37:27–32.
26a Моце 5:29, 49–52.
б 3 Ниф. 6:28;
Моце 4:6–12.
27a Моце 5:18–33.

28a Эхл. 11:1–4;
Ифер 1:3.
б Ифер 8:9, 15–25.
29a Хил. 2:4–13.
30a Алма 5:39–42;

Моро. 7:12, 17;
Моце 4:4.
31a 1 Ниф. 19:7.
32a Алма 46:8.

хийгээд гашуудлыг төрүүлж, тэд алдсууддаа улам автаж байв.

34 Мөн нифайчууд итгэлгүйдээ бууран доройтож, леменчүүд Бурханыхаа мэдлэгт үлэмж өсөж эхэлсэн тэр үед тэд, мөн ёс бусад мөн жигшүүрт хэргүүдэд автагдаж эхэлснийг бид ийн үзлээ; тийм ээ, тэд түүний дүрмүүдийг мөн зарлигуудыг дагаж, мөн түүний өмнө зөвөөр мөн үнэнээр алхаж эхлэв.

35 Мөн зүрх сэтгэлийнх нь ёс бус хийгээд хатуугийн учир, Их Эзэний Сүнс нифайчуудаас “холдож эхэлснийг бид ийн үзлээ.

36 Мөн тэдний үгсэд амархнаар мөн дуртайяа итгэсний учир леменчүүдийн дээр Их Эзэн Сүнсээ юүлж эхэлснийг бид тийн үзлээ.

37 Мөнхүү улиран тохиох дор Гадиантоны дээрэмчдийн бүлэглэлийг леменчүүд мөрдөв; мөн тэдний илүү ёс бус хэсгийн дунд Бурханы үгийг тэд номлосон аж, үүний хэрээр энэхүү дээрэмчдийн бүлэглэл леменчүүдийн дундаас бүрмөсөн устгагдсан байв.

38 Мөнхүү улиран тохиох дор нөгөөтэйгүүр, тэдний нууц аллагууд мөн хуйвалдаануудад тэдэнтэй нэгдэхээр, тэдний олзноос хүртэх мөн тэдний ажилд нь итгэх болтол зөв шударгыг үйлдэгчдийн ихэнх хэсгийг мэхлэн

дагуулж, нифайчуудын бүх нутаг даяар тархах хүртэл тэдний илүү ёс бус хэсгээс эхлээд нифайчууд тэднийг өөгшүүлж мөн дэмжив.

39 Мөн тэд тийн засгийн газрын цорын ганц удирдлагыг авч, үүний хэрээр тэд “ядуу бөгөөд номхон дөлгөөн, мөн Бурханы даруу дагалдагчдыг хөл дороо дэвсэлж мөн цохиж мөн зовоож мөн тэдэнд араа харуулав.

40 Мөн тэд аймшигт байдалд мөн үүрдийн устгалд “боловсорч гүйцээд байсныг бид тийн харлаа.

41 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын жаран найм дахь он тийн төгсөв.

Хиламаны хүү Нифайн бошиглол оршвой—Тэд ёс бус үйлүүдээ наманчлахгүй бол тэднийг бүрмөсөн устгалд хүргэн, уур хилэндээ тэдэнд зочлох болно хэмээн Бурхан Нифайн хүмүүст заналхийлэв. Бурхан Нифайн хүмүүсийг тахлаар цохив; тэд наманчилж мөн түүнд хандав. Лемен үндэстэн, Сэмуеэл нифайчуудад бошиглов.

7-гоос 16 дугаар бүлэгт агуулагдав.

БҮЛЭГ 7

Нифай умардад эсэргүүцэгдэж мөн Зарахемлад эргэж ирэв—

35a Мозая 2:36;
С ба Г 121:37;
39a Дуул. 109:16;

Алма 5:54–56;
С ба Г 56:16;
40a Хил. 5:2; 11:37;

С ба Г 18:6.

Тэрээр цэцэрлэгийнхээ цамхаг дээр залбирч мөн хүмүүст наманчлах эс бөгөөс мөхөхийг сануулан уриалав. Ойролцоогоор мээ 23–21 он.

Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор нифайчуудын хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын жаран есдүгээр онд Хиламаны хүү Нифай умардын нутгаас Зарахемлагийн нутагт “эргэж ирэв.

2 Учир нь тэрээр умардын нутагт байсан хүмүүсийн дунд явж, мөн Бурханы үгийг тэдэнд номлож, мөн тэдэнд олон зүйлийг бошиглосон бөлгөө;

3 Мөн тэд түүний бүх үгсийг эсэргүүцэж, үүний хэрээр тэрээр тэдний дунд үлдэж чадсангүй, харин төрөлх нутагтаа дахин эргэж иржээ.

4 Мөн хүмүүс тийм аймшигт ёс бусын байдалд буйг, мөн Гадиантоны дээрэмчид шүүлтийн суудлуудыг — уг нутгийн хүч чадал мөн эрх мэдлийг хууль бусаар булаан эзэлснийг; Бурханы зарлигуудыг хойш тавьж, түүний өмнө өчүүхэн ч зөв шударга байсангүйг; хүмүүний үрсэд зөв шударгыг үйлдсэнгүйг харжээ;

5 Зөв шударгынх нь учир зөв шударгыг үйлдэгсдийг буруушаахыг; гэмтнүүдийг мөн ёс бусыг үйлдэгсдийг мөнгөнийх нь учир үл шийтгэн явуулахыг; мөн үүнээс гадна тэд “дэлхийгээс нэр

алдар хийгээд эд хөрөнгө олж болохын тулд, мөн үүнээс гадна, тэд илүү амархнаар садар самууныг үйлдэж, мөн хулгайлж, мөн алж, мөн өөрсдийнхөө таалалуудын дагуу үйлдэж болохын тулд таалуудынхаа дагуу удирдаж мөн үйлдэхээр засгийн газрын тэргүүн албанд байхыг буюу—

6 Эдүгээ цөөн жилийн дотор энэ агуу алдас нифайчуудын дээр ирэв; мөн Нифай үүнийг хараад, зүрх нь цээжин дотроо харамслаар тэлэв; мөн тэрээр бодгалийн шаналалдаа дуу алдаж:

7 Ай, би түүнтэй хамт амлагдсан нутагт баясаж чадахын тулд өөрийн өвөг Нифай анх Иерусалим нутгаас гарах үед өөрийн өдрүүдийг өнгөрөөсөн болоосой би; тэгэхэд түүний хүмүүс анхаарлаа амархан хандуулдаг байж, Бурханы зарлигуудыг дагахдаа чанд, мөн алдсыг үйлдэхээр удирдагдахдаа удаан байжээ; мөн тэд Их Эзэний үгсийг дуулахдаа хурдан байжээ—

8 Тийм ээ, хэрэв миний өдрүүд тэдгээр өдрүүдэд байх боломжтой байсан аваас, ах дүүсийнхээ зөв шударгын учир бодгаль минь баясах сан билээ.

9 Гэвч болгоогтун, эдгээр нь миний өдрүүд байх нь, мөн ах дүүсийнхээ энэ ёс бусын учир бодгаль минь харамслаар дүүргэгдэх нь надад заяагдсан ажээ.

10 Мөн болгоогтун, эдүгээ улиран тохиох дор энэ нь За-рахемлагийн хотод байсан, төв зах тийш хүрэх тэр их хөлийн замын дэргэдэх, Нифайн цэцэрлэгт байсан нэгэн цамхаг дээр байв; тиймийн тул, түүнчлэн их хөлийн зам дэргэдүүр нь өнгөрөх цэцэрлэгийн хаалганы ойролцоо байсан цамхаг болох, өөрийн цэцэрлэг доторх тэрхүү цамхаг дээр Нифай өөрөө бөхийн суув.

11 Мөнхүү улиран тохиох дор цамхаг дээр Нифай Бурханд сэтгэлээ юүлж байхад хажуугаар өнгөрч мөн харсан хэдэн хүмүүн байв; мөн тэд гүйж мөн үзсэнээ хүмүүст хэлэв, мөн хүмүүсийн ёс бусын төлөө тийм агуу гашуудлын шалтгааныг мэдэж болохын тулд хүмүүс бөөн бөөнөөрөө цуглан ирэв.

12 Мөн эдүгээ, Нифай бо-сохдоо тэрээр нэгдэн цугларсан хүмүүс бөөгнөрснийг болгоов.

13 Мөнхүү улиран тохиох дор тэрээр амаа нээж мөн тэдэнд хэлэв: Болгоогтун, та нар “яагаад өөрсдөө нэгдэн цугларцгаасан билээ? Би өөрсдийн чинь алдсуудыг хэлж болохын тулд гэж үү?

14 Тийм ээ, би Бурхандаа сэтгэлээ юүлж болохын тулд цамхаг дээр гарсны учир нь, та нарын алдсуудын учир зүрх сэтгэлийн минь үлэмжийн их харамслын учир бөлгөө!

15 Мөн гашуудал мөн гаслангийн минь учир та нар нэгдэн цуглараад, мөн гайхаж байна; тийм ээ, мөн та нарт гайхах их хэрэгцээ буй; тийм ээ, та нар бууж өгснөөр чөтгөр та нарын зүрх сэтгэлд агуу байрыг эзэлсэн учир та нар гайхвал зохино.

16 Тийм ээ, та нарын бодгалийг үүрдийн аймшиг мөн төгсгөлгүй халаглалд доош чулуудахаар эрэлхийлж буй түүний уруу таталтанд та нар хэрхэн бууж өгч яаж чадна вэ?

17 Ай наманчлагтун та нар, наманчлагтун та нар! “Та нар яагаад үхэх билээ? Та нар эргэ, та нар Их Эзэн Бурханыхаа зүг эргэ. Тэрбээр яагаад та нарыг орхисон билээ?

18 Энэ нь та нар зүрх сэтгэлээ хатууруулсных бөлгөө; тийм ээ, та нар “сайн хоньчны дуу хоолойг анхааран сонсоогүй; тийм ээ, та нар өөрсдийнхөө эсрэг уурлуулахаар түүнийг бөдөөн хатгасан билээ.

19 Мөн болгоогтун, та нарыг “цуглуулахын оронд, та нар наманчлахгүй аваас, болгоогтун, тэрээр та нарыг тарааснаар та нар нохдын хийгээд зэрлэг араатнуудын идэш байх болно.

20 Ай, тэрбээр та нарыг чөлөөлсөн чухам тэрхүү өдөр та нар Бурханаа хэрхэн мартаж чадсан бэ?

21 Гэвч болгоогтун, энэ нь эд хөрөнгө олохын тулд,

13a Мат. 3:5–8.

17a Езек. 18:23, 31–32.

18a Езек. 34:12;

Иохан 10:14–16;

Алма 5:38–41, 57–60.

су Сайн Хоньчин.

б Иаков 1:8;

Алма 12:36–37.

19a 3 Ниф. 10:4–7.

хүмүүнээр магтуулахын тулд, тийм ээ, та нар алт болон мөнгө авч болохын тулд боллой. Мөн та нар зүрх сэтгэлээ энэ “дэлхийн баялгууд хийгээд хоосон зүйлүүд дээр байрлуулсан, үүнийхээ төлөө та нар алж, мөн тонож, мөн хулгайлж, мөн хөршийнхөө эсрэг ^бхуурамчаар гэрчилдэг, мөн бүхий л төрлийн алдсуудыг үйлддэг.

22 Мөн энэ шалтгааны учир, та нар наманчлахгүй аваас та нарын дээр халаг ирэх болно. Учир нь хэрэв та нар наманчлахгүй аваас, болгоогтун, энэ их хот, мөн түүнчлэн эргэн тойрон дахь бидний эзэмшлийн нутагт буй тэдгээр бүх агуу хотууд, та нар тэдний дотор байргүй байхын тулд булаан эзлэгдэх болно; учир нь болгоогтун, Их Эзэн эдүгээ хүртэл хийснийхээ адилаар, дайснуудаа сөрөн зогсох “хүчийг та нарт өгөхгүй.

23 Учир нь болгоогтун, Их Эзэн тийн хэлэв: Нүглүүдээ наманчилж, мөн үгсийг минь анхааран сонссон тэднээс бусдад бол, ёсон бусыг үйлдэгчдийг нэгийг нь нөгөөгөөс илүүд үзэж өөрийн хүчнээсээ үзүүлэхгүй. Эдүгээ тиймийн тул, ах дүүс минь, та нар наманчлахаас бусдаар та нарыг бодвол леменчүүдэд “илүү дээр байх болно гэдгийг та нар болгоогоосой хэмээнэ би.

24 Учир нь болгоогтун, тэд

та нараас илүү зөв шударга, учир нь тэд та нарын хүлээн авсан тэр агуу мэдлэгийн эсрэг нүгэл үйлдээгүй; тиймийн тул Их Эзэн тэдэнд нигүүлсэнгүй байх болно; тийм ээ, тэр ч байтугай та нар наманчлахгүй аваас бүрмөсөн “устгагдах үед ч тэрээр тэдний өдрүүдийг ^буртасгаж мөн үр удмыг нь өсгөх болно.

25 Тийм ээ, та нарын дунд ирсэн агуу жигшүүрт байдлын учир та нарт халаг болог; мөн та нар өөрсдийгөө үүнд, тийм ээ, Гадиантоноор байгуулагдсан “нууц бүлэглэлд нэгтгэсэн!

26 Тийм ээ, та нар зүрх сэтгэлдээ орохыг хүлцсэн, өөрсдийн үлэмж агуу “баялгуудын учир сайнаас хэтрүүлэн хэт хөөргөсөн бардамналын учир та нарт ^бхалаг ирэх болно!

27 Тийм ээ, та нарын ёс бус үйлүүд мөн жигшүүрт хэргүүдийн чинь учир та нарт халаг байг!

28 Мөн та нар наманчлахгүй аваас та нар мөхөх болно; тийм ээ, бүр газар нутгууд чинь та нараас булаан эзлэгдэж, мөн та нар газрын гадаргуу дээрээс устгагдах болно.

29 Болгоогтун эдүгээ, эдгээр зүйлүүд байх болно хэмээн би өөрөө мэдээд хэлээгүй, учир нь би эдгээр зүйлийг “мэдэж байгаа нь өөрөө бус юм; гэвч болгоогтун, Их Эзэн

21a су Дэлхийнх.

б Ег. 20:16;

Мат. 15:19–20.

22a Мозая 7:29.

23a Хил. 15:11–15.

24a Алма 9:19.

б Алма 9:16;

С ба Г 5:33.

25a Хил. 3:23.

26a Иаков 2:13.

б Иса. 5:8–25.

29a Алма 5:45–46.

Бурхан тэдгээрийг надад мэдүүлсэн учир би эдгээр зүйлүүд үнэнийг мэднэ, тиймийн тул тэдгээр нь байх болно хэмээн гэрчилж байна би.

БҮЛЭГ 8

Хуйвалдсан шүүгчид Нифайн эсрэг хүмүүсийг турхирахаар эрэлхийлэв—Абрахам, Мосе, Зинос, Зинок, Эсиас, Исаиа, Иеремиа, Лихай, мөн Нифай бүгд Христийн талаар гэрчлэв—Ерөнхий шүүгч алагдсаныг Нифай мэдэгдэв. Ойролцоогоор мээ 23–21 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Нифай эдгээр үгсийг хэлэхэд, болгоогтун, шүүгчид, түүнчлэн Гадантоны нууц бүлэглэлд харьяалагдсан эрс болох тэд уурлаж, мөн тэд түүний эсрэг хашгирч, хүмүүст хэлсэн нь: Та нар яагаад энэ хүнийг тэрээр хийсэн хэргийнхээ дагуу яллагдаж болохын тулд баривчилж мөн түүнийг нааш авчрахгүй байгаа билээ?

2 Та нар яагаад энэ хүнийг харж, мөн энэ хүмүүсийн эсрэг мөн хуулийн маань эсрэг доромжлохыг нь сонсоно вэ?

3 Учир нь болгоогтун, Нифай тэдэнд хуулийнх нь гуйвуулгын талаар ярьсан байв; тийм ээ, бичигдэх аргагүй олон зүйлийг Нифай ярьжээ; мөн тэрбээр Бурханы зарлигуудын эсрэг юу ч ярьсангүй.

4 Мөн тэдний харанхуйн

нууц ажлуудын талаар тэрээр тэдэнд тодорхой “ярьсан учир шүүгчид түүнд уурлаж байв; гэсэн хэдий ч, тэд өөрсдөө түүнд гар хүрч зүрхэлсэнгүй, учир нь хүмүүс тэдний эсрэг хашгиралдах болов уу хэмээн тэд айсан ажээ.

5 Тиймийн тул тэд хүмүүст хашгирч, хэлсэн нь: Та нар яагаад энэ хүн бидний эсрэг эсэргүүцэн доромжлохыг тэвчнэв? Учир нь болгоогтун тэрээр энэ бүх хүмүүсийг, бүр устгалд буруушааж байна; тийм ээ, мөн түүнчлэн бид тэдний дотор эзлэх байргүй байхын тулд манай их хотууд биднээс булаан авагдах болно.

6 Мөн эдүгээ энэ нь боломжгүйг бид мэднэ, учир нь болгоогтун, бид хүчирхэг, мөн хотууд маань агуу, тиймийн тул бидний дайснууд бидний дээр хүчгүй байх болно.

7 Мөнхүү улиран тохиох дор тэд Нифайн эсрэг хүмүүсийг уурлуулахаар тийн өдөөж, мөн тэдний дунд зөрчилдөөнүүд үүсгэв; учир нь тэнд байсан зарим нь хашгирч: Энэ хүнийг орхи, учир нь тэрээр сайн хүн, мөн бид наманчлахгүй аваас түүний хэлж буй зүйлүүд гарцаагүй улиран тохиох болно;

8 Тийм ээ, болгоогтун, бидэнд түүний гэрчилсэн бүх шийтгэлүүд бидний дээр ирэх болно; учир нь бидний алдсуудын талаар бидэнд тэр зөвөөр гэрчилснийг бид

мэднэ. Мөн болгоогтун тэдгээр нь олон, мөн тэрбээр алдсуудыг маань мэддэгийн адил бидэнд тохиох бүх зүйлийг “мэддэг бөлгөө.

9 Тийм ээ, мөн болгоогтун, хэрэв тэрбээр бошиглогч биш байсан бол тэдгээр зүйлийн талаар гэрчилж чадахгүй байх сан.

10 Мөнхүү улиран тохиох дор Нифайг устгахыг эрэлхийлсэн хүмүүс айдсынхаа учир албадуулагдсанаас, тэд түүнд гар хүрч зүрхэлсэнгүй; тиймийн тул заримын нүдэнд таалал олсноо хараад, тэрээр тэдэнд дахин ярьж эхлэв, үүний хэрээр тэднээс бусад нь айсан аж.

11 Тиймийн тул тэрээр тэдэнд илүү ихийг ярихаар албадагдаж, хэлсэн нь: Болгоогтун, ах дүүс минь, Бурхан нэгэн хүнд, бүр Мосед, “Улаан Тэнгисийн усыг цохих хүчийг өгсөн билээ, мөн тэдгээр нь нааш мөн цааш хуваагдаж, үүний хэрээр бидний эцэг өвгөд асан изриалчууд хуурай газар дээгүүр гарч ирсэн юм, мөн ус нь египетчүүдийн их цэргийн дээр хучин бууж мөн тэднийг залгисныг уншаагүй гэж үү?

12 Мөн эдүгээ болгоогтун, хэрэв Бурхан энэ хүнд ийм хүч өгсөн байхад, тэгвэл та нар яагаад өөр хоорондоо

маргалдаж, мөн та нар наманчлахгүй аваас та нарын дээр ирэх тэр шүүлтүүдийн талаар би мэдэж болох хүчийг тэр надад өгөөгүй хэмээн хэлэх болов?

13 Гэвч, болгоогтун, та нар зөвхөн миний үгсийг үгүйсгэх биш, харин та нар эцэг өвгөдөөрөө яригдсан бүх үгсийг ч, мөн түүнчлэн энэ хүн болох Мосегийн, тийм агуу хүч өгөгдсөн түүний ярьсан үгсийг ч бас, тийм ээ, Мессиагийн ирэлтийн талаар түүний ярьсан үгсийг ч түүнчлэн үгүйсгэж байгаа хэрэг.

14 Тийм ээ, тэрээр Бурханы Хүү ирнэ гэсэн цэдгийг үлдээгээгүй гэж үү? Мөн тэрээр аглаг буйдад гуулин могойг өргөсний адил, түүнчлэн ирэх тэр ч бас “өргөгдөх болно.

15 Мөн тэрхүү могойг харсан болгон “амьдрах байсны адил, тэрчлэн Бурханы Хүүг итгэлтэйгээр мөн гэмшсэн сэтгэлтэйгээр харсан болгон, бүр мөнхийн болох тэрхүү амьдралаар ^aамьдарч болох бөлгөө.

16 Мөн эдүгээ болгоогтун, ганцхан Мосе бус, харин түүнчлэн түүний өдрүүдээс бүр Абрахамын өдрүүдийг хүртэлх “бүх ариун бошиглогчид эдгээр зүйлийг гэрчилсэн юм.

8a Хил. 7:29.
11a Ег. 14:16;
1 Ниф. 17:26;
Мозая 7:19;
С ба Г 8:2–3;
Моце 1:25.

14a Тоол. 21:6–9;
2 Ниф. 25:20;
Алма 33:19–22.
су Есүс Христ—
Есүс Христийн
бэлэгдэл болон

хэв шинж.
15a 1 Ниф. 17:41;
Алма 37:45–47;
3 Ниф. 15:9.
b Иохан 11:25.
16a Иаков 4:4–5; 7:11.

17 Тийм ээ, мөн болгоогтун, “Абрахам түүний ирэлтийг харж, мөн баяр талархлаар дүүргэгдэж, баяссан юм.

18 Тийм ээ, мөн болгоогтун би та нарт хэлье, зөвхөн Абрахам эдгээр зүйлийн тухай мэдсэн юм биш, харин Абрахамын өдрүүдээс өмнө Бурханы “жаягаар дуудагдсан нь ^болон бөлгөө; тийм ээ, бүр түүний Хүүгийн жаягаар; мөн түүний ирэлтээс олон мянган жилийн өмнө ч, тэр ч байтугай гэтэлгэл тэдэнд ирэх болно гэдэг нь хүмүүст үзүүлэгдэж болохын тулд энэ нь байсан болой.

19 Мөн эдүгээ бүр Абрахамын өдрүүдээс хойш эдгээр зүйлийг гэрчилсэн олон бошиглогч байсныг та нар мэдээсэй хэмээнэ би; тийм ээ, болгоогтун, бошиглогч “Зинос зоригтойгоор гэрчилсэн билээ; үүнийхээ төлөө тэр алагдсан юм.

20 Мөн болгоогтун, түүнчлэн “Зинок, мөн түүнчлэн Эсиас, мөн түүнчлэн ^бИсаиа, мөн ^вИеремиа, (Иеремиа бол ^гИерусалимын устгалын тухай гэрчилсэн бошиглогч билээ) мөн эдүгээ бид Иеремиагийн үгсийн дагуу Иерусалим устгагдсаныг мэднэ. Ай тэгвэл түүний бошигло-

лын дагуу, Бурханы Хүү яагаад ирэхгүй гэж?

21 Мөн эдүгээ та нар “Иерусалим устгагдсан талаар маргах уу? Та нар Зедикаягийн ^бхөвгүүд, ^вМюлекээс бусад нь бүгд алагдаагүй гэж хэлэх үү? Тийм ээ, мөн та нар Зедикаягийн үр удам бидэнтэй хамт буйг, мөн тэд Иерусалимын нутгаас гаргагдсаныг болгоох нь үгүй гэж үү? Гэвч болгоогтун, энэ нь бүгд бус —

22 Тэрбээр эдгээр зүйлийн талаар гэрчилсэн учир бидний өвөг Лихай Иерусалимаас гаргагдсан билээ. Нифай, мөн түүнчлэн бидний бараг бүх эцэг өвгөд, бүр энэ цагийг хүртэл түүнчлэн эдгээр зүйлийн талаар гэрчилсэн юм; тийм ээ, тэд Христийн “ирэлтийн талаар гэрчилсэн, мөн хойшдыг харж, мөн ирэх түүний өдөрт баяссан билээ.

23 Мөн болгоогтун, тэр бол Бурхан мөн тэрээр тэдэнтэй хамт буй, мөн тэрээр өөрийгөө тэдэнд үзүүлсэн, тиймээс тэд түүгээр гэтэлгэгдсэн бөлгөө; мөн тэд ирэх зүйлийн учир түүнд алдар гавьяаг өгөх болно.

24 Мөн эдүгээ, та нар эдгээр зүйлийг мэддэг мөн та нар худал хэлэхээс бусдаар тэдгээрийг үгүйсгэж чадахгүйн

17a Эхл. 22:8–14;
Иохан 8:56.

18a су Мелкизедек санваар.
б Алма 13:19;
С ба Г 84:6–16; 136:37.

19a Алма 34:7.

20a 1 Ниф. 19:10;
3 Ниф. 10:15–16.

су Судрууд—
Алдагдсан судрууд.

б Иса. 53.
в 1 Ниф. 5:13; 7:14.
г Иер. 26:18;
1 Ниф. 1:4.

21a 2 Ниф. 6:8;
Омнаи 1:15.
б Хаад. дэд 25:7;

Иер. 39:6; 52:10.
в Езек. 17:22–23;
Хил. 6:10.

22a су Есүс Христ—
Есүс Христийн төрөлт болон нас баралтын тухай бошиглогч.

учир, тиймийн тул үүнд та нар нүгэл үйлдсэн, учир нь та нар, ийм олон нотолгоо хүлээн авсан хэдий ч эдгээр бүх зүйлийг эсэргүүцсэн тэр; тийм ээ, та нар бүр “бүх зүйлийг хүлээн авсан, тэнгэр дэх зүйлүүд, мөн газар дээрх бүх зүйлийг аль алиныг нь, нэгэн гэрчлэгчийн адилаар тэдгээр нь үнэн болохыг хүлээн авсан билээ.

25 Гэвч болгоогтун, та нар үнэнийг үгүйсгэж, мөн ариун Бурханыхаа эсрэг “эсэргүүцсэн; мөн бүр энэ цагт, цэвэр бус юухан ч орж чадахгүй тэнд юу ч ялзардаггүй тэнгэрт өөрсдөдөө эрдэнэс ^бхураахын оронд та нар “шүүлтийн өдөрт өөрсдөдөө уур хилэнг овоолон бөөгнүүлэх юм.

26 Тийм ээ, бүр энэ цаг үед ч та нар аллагуудынхаа мөн “завхайрлынхаа мөн ёс бусынхаа учир үүрдийн устгалд боловсорч байна; тийм ээ, мөн та нар наманчлахгүй аваас энэ нь та нарт удахгүй ирэх болно.

27 Тийм ээ, болгоогтун энэ нь эдүгээ үүдэн дээр чинь байна; тийм ээ, та нар шүүлтийн суудалд очиж, мөн үзэцгээ; мөн болгоогтун, шүүгч чинь алагдсан буй, мөн тэр цусандаа хутгалдан “хэвтэж байгаа; мөн шүүлтийн суудалд суухыг эрэлхийлсэн ^бдүүдээ тэрээр алагджээ.

28 Мөн болгоогтун, Гадан-

тон мөн хүмүүний бодгалийг устгахыг эрэлхийлэх хилэнцэт нэгнээр “үүсгэгдсэн та нарын нууц бүлэглэлд тэдний аль аль нь харьяалагддаг билээ.

БҮЛЭГ 9

Ерөнхий шүүгч шүүлтийн суудалдаа үхсэнийг элч нар олов — Тэд гянданд хоригдож мөн хожим нь суллагдав — Сийн тумыг алуурчин хэмээн Нифай бурханлиг нөлөөгөөр таньж тогтоов — Нифай заримаар нь бошиглогч хэмээн хүлээн зөвшөөрөгдөв. Ойролцоогоор мээ 23–21 он.

Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор Нифай эдгээр үгсийг ярьсны дараа, тэдний дунд байсан хэдэн хүн шүүлтийн суудлын зүг гүйж одов; тийм ээ, бүр явсан нь тав байв, мөн тэд явах зуураа өөр хоорондоо хэлэлцэв:

2 Болгоогтун, эдүгээ энэ хүн бошиглогч мөн эсэхийг мөн Бурхан ийм гайхам зүйлүүдийг бидэнд бошиглохыг түүнд зарлигласан эсэхийг бид гарцаагүй мэдэх болно. Болгоогтун, тэр тэгсэн гэдэгт бид итгэхгүй байна; тийм ээ, бид түүнийг бошиглогч гэдэгт итгэхгүй байна; гэсэн хэдий ч, хэрэв ерөнхий шүүгчийн талаар түүний хэлсэн энэ зүйл үнэн байж, тэрээр үхсэн байвал, тэгвэл бид

24a Алма 30:44;

Мосе 6:63.

25a Мозая 2:36–38; 3:12.

б Хил. 5:8;

3 Ниф. 13:19–21.

в С ба Г 10:20–23;

121:23–25.

26a су Садар самуун.

27a Хил. 9:3, 15.

б Хил. 9:6, 26–38.

28a Хил. 6:26–30.

түүний ярьсан бусад үг нь ч үнэн гэдэгт итгэнэ.

3 Мөнхүү улиран тохиох дор тэд чадлаараа гүйж мөн шүүлтийн суудалд ирэв; мөн болгоогтун, ерөнхий шүүгч газарт унаж, мөн цусандаа хутгалдан “хэвтэж байв.

4 Мөн эдүгээ болгоогтун, тэд үүнийг хараад тэд үлэмж гайхан цочирдож, үүний хэрээр тэд газар унав; учир нь тэд ерөнхий шүүгчийн талаар Нифайн ярьсан үгсэд итгээгүй байжээ.

5 Гэвч эдүгээ, тэд хараад итгэж, мөн Нифайн ярьсан тэр бүх шүүлтүүд уг хүмүүсийн дээр ирэх болуузай хэмээх айдас тэдний дээр ирэв; тиймийн тул тэд салгалан, мөн газарт унасан ажээ.

6 Эдүгээ, шүүгч алагдсан тэр даруй — тэрээр дүрээ хувиргасан дүүдээ хутгалуулсан байж, мөн тэр нь зугтаж, мөн зарц нар нь гүйлдэж бас хүмүүст хэлэв, тэдний дунд аллагын зар түгэв;

7 Мөн болгоогтун хүмүүс шүүлтийн суудал буй тэр газарт нэгдэн цугларч — мөн болгоогтун, газарт унасан таван эрийг тэд гайхан харцгаав.

8 Мөн эдүгээ болгоогтун, уг хүмүүс Нифайн “цэцэрлэгт цугларсан тэрхүү хүмүүсийн талаар юу ч мэдсэнгүй; тиймийн тул тэд өөр хоорондоо хэлэлцэж: Шүүгчийг алсан тэд бол эдгээр эрчүүд болой, мөн тэд биднээс зугтаж

чадахгүйн тул Бурхан тэднийг цохьжээ хэмээцгээв.

9 Мөнхүү улиран тохиох дор тэд тэднийг баривчилж мөн тэднийг хүлээд мөнхүү тэднийг шоронд хаялаа. Мөн шүүгч алагдсан хийгээд, мөн алуурчид нь баривчлагдаж, шоронд хаягдсан хэмээх тунхаг бичиг тараагдан илгээгдэв.

10 Мөнхүү улиран тохиох дор маргааш нь хүмүүс алагдсан агуу ерөнхий шүүгчийнхээ оршуулган дээр гашуудан мөн “мацаг барихаар чуулан цуглацгаав.

11 Мөн түүнчлэн Нифайн цэцэрлэгт байж, мөн түүний үгсийг сонссон шүүгчид ч тийн, оршуулган дээр нэгдэн цугларсан байв.

12 Мөнхүү улиран тохиох дор тэд хүмүүсийн дунд сураглаж, хэлрүүн: Ерөнхий шүүгч үхсэн эсэхийг сураглуулахаар илгээсэн таван хүн хаана байна? Мөн тэд хариулж мөн хэлэв: Та нарын илгээсэн гэх тэр тавын талаар бид мэдэхгүй; харин бидний шоронд хаясан, алуурчид болох тэр тав бий.

13 Мөнхүү улиран тохиох дор шүүгчид тэднийг авчрахыг хүсэв; мөн тэд авчрагдаж, мөн болгоогтун илгээгдсэн тав нь тэд байв; мөн болгоогтун шүүгчид тэднээс уг хэргийн талаар мэдэхээр асууж, мөн тэд өөрсдийн үйлдсэн бүгдийг тэдэнд өгүүлж, хэлсэн нь:

14 Бид гүйлдэж мөн шүүлтийн суудал буй тэр газар

ирсэн, мөн бүх зүйл бүр Нифайн гэрчилсний дагуу байхыг бид үзэж, бид гайхшираад, үүний хэрээр бид газарт унасан; мөн биднийг ухаан ороход, болгоогтун тэд биднийг шоронд хаясан болгоо.

15 Эдүгээ, энэ хүн алагдсан талаар, хэн үүнийг үйлдсэнийг бид мэдэхгүй; мөн зөвхөн энэ зэргийг л бид мэднэ, бид та нарын хүссэний дагуу гүйж мөн ирсэн, мөн болгоогтун Нифайн үгсийн дагуу, тэр үхчихсэн байсан.

16 Мөн эдүгээ улиран тохиох дор шүүгчид уг хэргийг хүмүүст тайлбарлаж, мөн Нифайн эсрэг хашгиралдан, өгүүлсэн нь: Болгоогтун, тэрээр биднийг өөрийн сүсэг бишрэлд урвуулж болохын тулд, тэрээр агуу хүн, Бурханаар сонгогдсон мөн бошиглогч хэмээн өөрийгөө өргөмжилж болохын тулд, дараа нь тэрээр үүнийг бидэнд тунхаглаж болохын тулд энэ нифай шүүгчийг алахаар хэн нэгэнтэй тохиролцсон байх ёстойг бид мэднэ.

17 Мөн эдүгээ болгоогтун, бид энэ хүнийг илчлэх болно, мөн тэрээр буруугаа хүлээж мөн энэ шүүгчийн алуурчин чухам хэн болохыг бидэнд мэдүүлэх болно.

18 Мөнхүү улиран тохиох дор сайхь тав оршуулгын өдөр суллагдав. Гэсэн хэдий ч, Нифайн эсрэг ярьсан түүний үгсийн талаар тэд шүүгчдийг

буруутгаж, мөн тэдэнтэй нэг нэгээрээ зөрөлдөв, үүний хэрээр тэд тэднийг хэлэх үггүй болгов.

19 Гэсэн хэдий ч, тэд Нифайг баривчлагдаж мөн хүлэгдэж мөн цугласан олны өмнө авчрагдахаар болгож, мөн тэд түүнийг үхэлд хүргэхээр буруутгаж болохын тулд, үгсийг нь авцалдахгүй болгохоор янз янзын аргаар түүнийг шалгааж эхлэв —

20 Түүнд хэлэв: Чи бол хамсаатан нь; энэ аллагыг үйлдсэн хүн хэн бэ? Эдүгээ бидэнд хэлэгтүн, мөн буруугаа хүлээн зөвшөөр; хэлрүүн, Болгоогтун мөнгө энэ байна; мөн хэрэв чи бидэнд хэлэх юм бол, мөн түүнтэй хийсэн гэрээ байгаагаа хүлээвэл бид амийг чинь түүнчлэн хэлтрүүлэх болно.

21 Гэвч Нифай тэдэнд хэлэв: Ай “мунхаг та нар, зүрх сэтгэл нь хөндөгдөөгүй та нар, харалган та нар, мөн “зөрүүд хүмүүс та нар, энэхүү нүглийн замаараа явсаар байхыг чинь Их Эзэн Бурхан тань хэр удаан хүлцэхийг та нар мэдэх үү?

22 Ай та нар наманчлахгүй аваас, энэ үед та нарыг хүлээх агуу устгалын учир орь дуу тавин мөн “гашуудаж эхэлбэл зохино, та нар.

23 Болгоогтун манай ерөнхий шүүгч Сизромыг алуулахаар хэн нэгэн хүнтэй намайг зөвшилцсөн хэмээн та нар хэлж байна. Гэвч болгоогтун,

би та нарт хэлнэ, энэ зүйлийг та нар мэдэж болохын тулд би та нарт гэрчилсний улмаас энэ болой, тийм ээ, бүр би та нарын дундах ёс бус үйлүүд хийгээд жигшүүрт хэргүүдийг мэдсэнийг та нарт гэрчлэх гэрчлэлийн тулд билээ.

24 Мөн би үүнийг үйлдсэн учир, энэ зүйлийг үйлдүүлэхээр хэн нэгэнтэй намайг зөвшилцсөн хэмээн та нар хэлж байна; тийм ээ, би та нарт энэ тэмдгийг үзүүлсэн учир та нар надад уурлаж, амийг минь егүүтгэхийг эрэлхийлж байна.

25 Мөн эдүгээ болгоогтун, би та нарт өөр нэгэн тэмдэг үзүүлэх болно, мөн та нар энэ зүйлийн учир намайг устгахыг эрэлхийлэх эсэхийг үзье.

26 Болгоогтун би та нарт хэлнэ: Сизромын “дүү нь болох, Сийнтумын гэрт очиж, мөн түүнд хэл—

27 Бошиглогчийн дүр үзүүлэгч, нифай энэ хүмүүсийн талаар их хилэнцтийг бошиглох тэрбээр, ах чинь болох Сизромыг алахад чинь, тантай зөвшилцсөн үү?

28 Мөн болгоогтун, тэрээр та нарт, Үгүй гэж хэлэх болно.

29 Мөн та нар түүнд хэлэх болно: Та ахыгаа алсан уу?

30 Мөн тэрээр айн зогсож, мөн юу хэлэхээ мэдэхгүй байх болно. Мөн болгоогтун, тэрээр та нарт үгүйсгэх болно; мөн тэрээр гайхширч балмагдсан лугаа адил үйлдэх болно; гэсэн хэдий ч,

тэрээр гэмгүй гэдгээ та нарт тунхаглах болно.

31 Гэвч болгоогтун, та нар түүнийг шалгах болно, мөн та нар түүний нөмрөгийн хормой дээрх цусыг олох болно.

32 Мөн та нар үүнийг хараад, та нар хэлнэ: Хаанаас энэ цус болов? Энэ бол танай ахын цус гэдгийг бид мэдэхгүй гэж үү?

33 Мөн тэгэхэд тэрээр салгалж, мөн бүр түүний дээр үхэл ирсэн мэтээр тэр цонхигор харагдах болно.

34 Мөн тэгэхэд та нар хэлнэ: Энэ айдсыг мөн царайд чинь тодрох тэр цонхигор байдлын учир, болгоогтун, гэмтэйг тань бид мэдэв.

35 Мөн тэгэхэд илүү их айдас түүний дээр ирэх болно; мөн тэгээд тэрээр хүлээж, мөн энэхүү аллагыг хийснээ цаашид үгүйсгэхгүй болой.

36 Мөн тэгээд тэрээр та нарт, Бурханы хүчээр надад өгөгдөхөөс бусдаар бол уг хэргийн талаар Нифай намайг юу ч мэдэхгүй хэмээн хэлэх болно. Мөн тэгэхэд та нар намайг шударга хүн, мөн би бол Бурханаас та нарт илгээгдсэнийг мэдэх болно.

37 Мөнхүү улиран тохиох дор тэд одож, мөн, бүр Нифайн тэдэнд хэлсний дагуу үйлдэв. Мөн болгоогтун, түүний хэлсэн үгс үнэн байв; учир нь тэрхүү үгсийн дагуу тэрээр үгүйсгэж; мөн түүнчлэн

тэрхүү үгсийн дагуу тэрээр хүлээв.

38 Мөн тэрээр өөрөө тэрхүү алуурчин гэдгээ нотлохоор авчрагдсан байв, үүний хэрээр мөнөөх тав мөн түүнчлэн Нифай чөлөөлөгдөв.

39 Мөн нифайчуудаас Нифайн үгсэд итгэсэн зарим нь байв; мөн тэрхүү тавын гэрчлэлийн улмаас түүнчлэн итгэсэн зарим нь байв, учир нь тэд шоронд байхдаа хөрвүүлэгдсэн байв.

40 Мөн эдүгээ хүмүүсийн дунд Нифай бол бошиглогч хэмээн хэлдэг зарим нь байв.

41 Мөн ийн хэлэх бусад зарим нь байв: Болгоогтун, тэр бол нэгэн бурхан, учир нь тэр нэгэн бурхан бус аваас бүх зүйлийг мэдэж чадахгүй байсан билээ. Учир нь болгоогтун, тэрээр зүрх сэтгэлийн маань бодлуудыг хэлсэн, мөн түүнчлэн юмсыг хэлсэн бидэнд билээ; мөн тэрээр бүр ерөнхий шүүгчийг маань алсан жинхэнэ алуурчныг бидний мэдлэгт авчирсан бөлгөө.

БҮЛЭГ 10

Их Эзэн лацдах хүчийг Нифайд өгөв—Тэрээр газарт мөн тэнгэрт холбох мөн цуцлах хүчийг хүлээн авав—Тэрээр наманчлахыг эс бөгөөс мөхөхийг хүмүүст зарлиглав—Сүнс түүнийг цугласан олноос цугласан олонд хүргэж байв. Ойролцоогоор мээ 21–20 он.

Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн дунд хагарал үүсч, үүний хэрээр тэд нааш цааш хуваагдаж мөн тэдний дунд зогсож байхад нь Нифайг ганцааранг нь орхин, тэд замаараа одоцгоов.

2 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн өөрт нь үзүүлсэн зүйлүүдийн талаар “эргэцүүлсээр Нифай гэр рүүгээ чиглэн замаараа одов.

3 Мөнхүү улиран тохиох дор түүнийг ийн эргэцүүлэх зуур—тэрээр Нифайн хүмүүсийн ёс бус үйлүүд, тэдний харанхуйн нууц ажлууд, мөн тэдний аллагууд мөн тэдний тонуулууд, мөн бүх төрлийн алдсуудынх нь учир ихэд гутарч байв—мөн улиран тохиох дор түүнийг зүрх сэтгэлдээ ийн эргэцүүлж байх зуур, болгоогтун, нэгэн дуу хоолой түүнд ирж хэлрүүн:

4 Адислагдсан болой чи, Нифай, чиний хийсэн зүйлүүдийн учир; учир нь чамд миний өгсөн үгийг энэ хүмүүст “ядрахаа мэдэхгүй яаж тунхагласныг чинь би болгоосон. Мөн чи тэднээс айсангүй, мөн “амьдралаа эрэлхийлсэнгүй, харин миний “тааллыг, мөн зарлигуудыг минь дагахыг эрэлхийллээ.

5 Мөн эдүгээ, чи үүнийг ингэж ядрахаа мартан хийсэн учир, болгоогтун, би чамайг үүрд адислах болно; мөн би чамайг үгэнд мөн үйлэнд, итгэлд мөн ажилд ч хүчирхэг

болгох болно; тийм ээ, бүр “бүх зүйл чиний” үгийн дагуу чамд хийгдэх болно, учир нь тааллын минь эсрэг зүйлийг ч “эс гуйдаг билээ.

6 Болгоогтун, чи бол Нифай, мөн бибээр Бурхан. Болгоогтун, чи энэ хүмүүсийн дээр хүчтэй байна, мөн энэ хүмүүсийн ёс бус үйлүүдийн дагуу газрыг “өлсгөлөнгөөр, мөн тахлаар, мөн устгалаар цохих болно хэмээн тэнгэр элчүүдийнхээ дэргэд би үүнийг чамд тунхаглаж байна.

7 Болгоогтун, Би чамд хүчийг өгье, иймээс газарт “лацадсан болгон чинь тэнгэрт лацдагдах болно; мөн газарт цуцалсан бүхэн чинь тэнгэрт цуцлагдах болно; мөн энэ хүмүүсийн дунд чамд тийм хүч байх болно.

8 Мөн тийн, хэрэв чи энэ ариун сүмд хоёр хуваагдан цуур гэж хэлэх аваас энэ нь хийгдэх болно.

9 Мөн хэрэв чи энэ “ууланд, чи нурж мөн тал бол гэж хэлбэл, энэ нь хийгдэх болно.

10 Мөн болгоогтун, хэрэв Бурхан энэ хүмүүсийг цохих болно гэж чи хэлэх аваас, энэ нь улиран тохиох болно.

11 Мөн эдүгээ болгоогтун, чи явж, та нар наманчлахгүй аваас, бүр “устгалд хүргэн цохигдох болно гэж Бүхнийг чадагч Их Эзэн Бурхан ийн хэлж байна хэмээн мөн энэ

хүмүүст тунхаглахыг би чамд зарлиг болгож байна буюу.

12 Мөн болгоогтун, эдүгээ улиран тохиох дор Их Эзэн эдгээр үгсийг Нифайд ярьсны дараа, тэрээр зогсож мөн гэртээ одсонгүй, харин нутгийн гадаргуу дээр тархсан хүмүүсийн зүг эргэж очоод, мөн хэрэв тэд наманчлахгүй аваас тэдний устгалын талаарх түүнд яригдсан Их Эзэний үгийг тэдэнд тунхаглаж эхлэв.

13 Эдүгээ болгоогтун, Нифай тэдэнд ерөнхий шүүгчийн үхлийн талаар хэлсэн нь агуу гайхамшиг байсан хэдий ч, тэд зүрх сэтгэлээ хатууруулж мөн Их Эзэний үгсийг анхааран сонссонгүй.

14 Тиймийн тул Нифай тэдэнд Их Эзэний үгийг тунхаглаж, өгүүлсэн нь: Та нар наманчлахгүй аваас, та нар бүр устгалд хүргэн цохигдох болно хэмээн Их Эзэн хэлэв.

15 Мөнхүү улиран тохиох дор тэрхүү үгийг Нифай тэдэнд тунхаглахад, болгоогтун, тэд зүрх сэтгэлээ хатууруулсан хэвээр байж мөн түүний үгсийг анхааран сонсохгүй байв; тиймийн тул тэд түүний эсрэг доромжлон, мөн түүнийг шоронд хаяж болохын тулд түүнд гар хүрэхийг завдав.

16 Гэвч болгоогтун, Бурханы хүч түүн дээр оршиж, мөн тэд түүнийг шоронд хаяхаар

5а 3 Ниф. 18:20;
С ба Г 88:63–65.
б Инос 1:12.
в 2 Ниф. 4:35;
С ба Г 46:30.

6а Хил. 11:4–18.
7а Мат. 16:19.
су Лацдах,
Лацдалт.
9а Мат. 17:20;

Иаков 4:6;
Морм. 8:24;
Ифер 12:30.
11а Хил. 5:2.

баривчилж чадсангүй, учир нь тэрээр Сүнсээр авагдаж мөн тэдний дундаас зөөгдөн одов.

17 Мөнхүү улиран тохиох дор тэрээр тийн Сүнсний нөлөөн дор, цугласан олноос цугласан олонд очиж, Бурханы үгийг, бүр тэдэнд бүгдэд нь тунхаглаж, өөрөөр хэлбэл бүх хүмүүсийн дунд илгээх хүртлээ тунхагласан билээ.

18 Мөнхүү улиран тохиох дор тэд түүний үгсийг анхааран сонсохгүй байв; мөн зөрчилдөөнүүд эхэлж, үүний хэрээр тэд өөр хоорондоо хуваагдаж мөн нэг нэгнээ илдээр хөнөөж эхлэв.

19 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын далан нэгдүгээр он ийн төгсөв.

БҮЛЭГ 11

Тэдний дайныг өлсгөлөнгөөр орлуулахаар Нифай Их Эзэнийг ятгав—Олон хүн мөхөв—Тэд наманчилж, мөн бороо оруулахыг Нифай Их Эзэнээс хичээнгүйлэн гуйв—Нифай Лихай хоёр олон илчлэлт хүлээж авав—Гадиантоны дээрэмчид өөрсдийгөө уг нутагт бэхлэн байрлуулав. Ойролцоогоор мээ 20–6 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор шүүгчдийн засаглалын далан хоёр дахь онд зөрчилдөөнүүд нэмэгдэж, үүний хэрээр Нифайн бүх хүмүүсийн дунд бүх нутаг даяар дайнууд байв.

2 Мөн устгалын мөн ёс бус

үйлүүдийн энэ ажлыг өдөөгчид нь дээрэмчдийн энэхүү “нууц бүлэглэл байв. Мөн энэ дайн бүтэн жил үргэлжилж; мөн далан гуравдугаар онд ч энэ нь түүнчлэн үргэлжлэв.

3 Мөнхүү улиран тохиох дор энэ онд Нифай Их Эзэнээс гуйн залбирч, хэлсэн нь:

4 Ай Их Эзэн, энэ хүмүүсийг илдээр устгагдахыг бүү хүлцээч; харин Ай Их Эзэн, түүний оронд тэд наманчилж мөн танд хандаж магадын тул Их Эзэн Бурханаа санахад тэднийг өдөөн хатгаж, энэ нутагт “өлсгөлөнг байлгаач.

5 Мөн үүнчлэн энэ нь Нифайн үгсийн дагуу хийгдэв. Мөн уг нутгийн дээр, Нифайн бүх хүмүүсийн дунд их өлсгөлөн болов. Мөн далан дөрөвдүгээр онд тийн өлсгөлөн үргэлжилж, мөн устгалын ажил нь илдээр байхаа больж харин өлсгөлөнгөөр улам гаарав.

6 Мөн энэхүү устгалын ажил түүнчлэн далан тавдугаар онд ч үргэлжлэв. Газар цохигдсон учир хуурай байж, мөн үр тарианы улиралд үр тариа гарсангүй; мөн бүхэл газар дэлхий цохигдож, бүр нифайчуудын дундахтай нэгэн адил леменчүүдийн дунд, үүнчлэн уг нутгийн илүү ёс бус хэсэгт нь тэд мянга мянгаараа мөхөхөөр, тэд цохигдов.

7 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс тэд өлсгөлөнгөөр мөхөх гэж буйгаа хараад, мөн тэд Их Эзэн Бурханаа “санаж

эхлэв; мөн тэд Нифайн үгсийг санаж эхлэв.

8 Мөн уг хүмүүс ерөнхий шүүгчдээсээ мөн удирдагчдаасаа, тэд Нифайд ийн хэлэхийг гуйж эхлэв: Болгоогтун, бид таныг Бурханы хүн гэдгийг мэднэ, мөн тиймийн тул бидний устгалын талаар таны ярьсан бүх “үгс биелэгдэхгүйн тулд тэр энэ өлсгөлөнг биднээс зайлуулаач хэмээн Их Эзэн бидний Бурханаас гуйгаач.

9 Мөнхүү улиран тохиох дор шүүгчид хүсэгдсэн энэхүү үгсийн дагуу, Нифайд хэлэв. Мөнхүү улиран тохиох дор хүмүүс наманчилж мөн таар өмсөн өөрсдийгөө даруу болгосныг Нифай үзээд, тэрээр Их Эзэнд дахин залбиран гуйж, хэлрүүн:

10 Ай Их Эзэн, болгоогтун энэ хүмүүс наманчлав; мөн тэд дундаасаа Гадиантоны бүлэглэлийг шүүрдэн зайлуулж, үүний хэрээр тэд үгүй болж, мөн тэдний нууц төлөвлөгөөнүүдийг газарт далдлан нуужээ.

11 Эдүгээ, Ай Их Эзэн, тэдний энэхүү даруу байдлын учир та уур хилэнгээ буцаана уу, мөн таны аль хэдийн устгасан ёс бус хүмүүний устгалд таны хилэн тайтгараг.

12 Ай Их Эзэн, та уур хилэнгээ, тийм ээ, догшин ширүүн хилэнгээ буцаан мөн энэ нутагт өлсгөлөн зогсож болохын тулд үйлдэнэ үү.

13 Ай Их Эзэн, та намайг сонсож, мөн энэ нь миний үгсийн дагуу хийгдэхээр болгож, мөн тэр нь үр жимсээ мөн үр тарианы улиралд үр тариагаа өгч болохын тулд газрын гадаргуу дээр “хур бороо илгээнэ үү.

14 Ай Их Эзэн, намайг, илдээр таригдах тахал зогсож болохын тулд, өлсгөлөн байг гэж хэлэхэд та “үгсийг минь сонссон билээ; мөн: Хэрэв энэ хүмүүс наманчилбал би тэднийг хэлтрүүлэх болно хэмээн та хэлсэн учир, бүр энэ үед ч та үгсийг минь сонсох болно гэдгийг би мэднэ.

15 Тийм ээ, Ай Их Эзэн, мөн тэдний дээр ирсэн тэрхүү өлсгөлөн хийгээд тахал мөн устгалын учир тэд наманчилсныг та харж байна.

16 Мөн эдүгээ, Ай Их Эзэн, та уур хилэнгээ зайлуулан буцааж, мөн тэд танд үйлчлэх эсэхийг нь дахин сорино уу? Мөн хэрэв тийн байваас, Ай Их Эзэн, та хэлсэн үгсийнхээ дагуу тэднийг адисалж чадах билээ.

17 Мөнхүү улиран тохиох дор далан зургадугаар онд Их Эзэн уур хилэнгээ хүмүүсээс буцааж, мөн газарт “бороо оруулахаар болгож, үүний хэрээр энэ нь үр жимсний улиралдаа үр жимсээ өгөв. Мөнхүү улиран тохиох дор үр тарианыхаа улиралд үр тариагаа өгөв.

18 Мөн болгоогтун, уг

хүмүүс баярлаж мөн Бурханыг алдаршуулав, мөн бүх газрын гадаргуу баяр баяслаар дүүргэгдэв; мөн тэд Нифайг устгахыг цаашид эрэлхийлсэнгүй, харин тэд түүнийг “агуу бошиглогч, мөн Бурханаас агуу хүч хийгээд эрх мэдэл өгөгдсөн Бурханы хүний хувьд хүндлэн хүндлэх болов.

19 Мөн болгоогтун, түүний дүү, Лихай зөв шударгад хамаарагдах зүйлүүдийн хувьд түүний ард “жаахан ч хоцорсонгүй.

20 Мөн ийн улиран тохиох дор Нифайн хүмүүс уг нутагт дахин дэгжиж эхлэв, мөн орхигдсон газруудаа дахин сэргээн босгож эхлэв, мөн бүр тэд уг нутгийн бүх гадаргууг бүрхэх хүртлээ, бас умардад мөн өмнөдөд ч, өрнөд тэнгисээс дорнод тэнгисийг хүртэл өнөржин мөн тархаж эхлэв.

21 Мөнхүү улиран тохиох дор далан зургадугаар он амар амгаланд төгсгөв. Мөн далан долдугаар он амар амгаланд эхлэв; мөн бүх нутгийн гадаргуу дээгүүр “сүм тархав; мөн хүмүүсийн ихэнх хэсэг нь нифайчууд хийгээд леменчүүдийн аль аль нь сүмд харьяалагдсан байлаа; мөн уг нутагт үлэмж агуу амар амгалан тэдэнд байв; мөн далан долдугаар он тийн төгсөв.

22 Мөн бошиглогчдоор байгуулагдсан сургаалын заалтуудын талаар цөөн хэдэн зөрчилдөөнүүд байсныг эс тооцвол, далан наймдугаар

онд түүнчлэн амар амгалан тэдэнд байв.

23 Мөн далан есдүгээр онд их маргаан байж эхлэв. Гэвч улиран тохиох дор Нифай, Лихай хоёр сургаалын үнэн заалтуудын талаар мэдсэн тэдний ах дүүсийн олон нь, өдөр бүр олон “илчлэлт хүлээн авсан учир, тиймийн тул тэд хүмүүст номлож, үүний хэрээр тэд мөнхүү онд тэдний маргааныг төгсгөл болгов.

24 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын наядугаар онд, хэдэн жилийн өмнө леменчүүдэд очиж, мөн өөрсдийн дээр леменчүүдийн нэрийг авсан Нифайн хүмүүсээс тэрслэгчдийн тодорхой тооны хэд нь, мөн түүнчлэн леменчүүдийн жинхэнэ үр удам асан тодорхой тооны хэд нь, тэднээр өөрөөр хэлбэл тэдгээр тэрслэгсдээр уурлуулахаар өдөөн хатгагдсан учир, тиймийн тул тэд ах дүүстэйгээ дайн эхлэв.

25 Мөн тэд аллага хийгээд тонуул үйлдэж; мөн тэгээд тэд ууланд, мөн аглаг буйдад мөн нууц газрууддаа буцаж ухраад, тэд илчлэгдэж болохооргүйгээр өөрсдийгөө нууж байв, мөн тэдэнд очих тэрслэгсэд байсны хэрээр тэд өдөр бүр тооны хувьд нэмэгдэж байв.

26 Мөн тийн хэсэг хугацаанд, тийм ээ, бүр олон бус жилийн дотор, тэд дээрэмчдийн үлэмж агуу бүлэглэл

болов; мөн тэд Гадиантоны бүх нууц төлөвлөгөөнүүдийг хайн олсон аж; мөн тэд тийн Гадиантоны дээрэмчид болов.

27 Эдүгээ болгоогтун, эдгээр дээрэмчид агуу устгал, тийм ээ, бүр нифайчуудын ардын дунд, мөн түүнчлэн леменчүүдийн ардын дунд агуу устгалыг тарив.

28 Мөнхүү улиран тохиох дор энэ устгалын ажил зогсоогдох нь зайлшгүй байв; тиймийн тул тэд аглаг буйдад мөн уулсын дээр, дээрэмчдийн энэ бүлэглэлийг хайж олоод, мөн тэднийг устгахаар хүчирхэг эрсийн их цэргийг илгээв.

29 Гэвч болгоогтун, улиран тохиох дор мөнхүү онд тэд бүр өөрийн нутаг тийш туугдан ухраагдав. Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын наядугаар он тийн төгсөв.

30 Мөнхүү улиран тохиох дор наяннэгдүгээр оны эхэнд тэд дахин дээрэмчдийн энэ бүлэглэлийн эсрэг явж, мөн олныг нь устгав; мөн тэд түүнчлэн их устгалаар зочлогдов.

31 Мөн ууланд болон аглаг буйдад бужигнах дээрэмчдийн үлэмж агуу тооны учир, тэд аглаг буйдаас болон уулнаас нутагтаа буцаж очихоор дахин албадуулагдав.

32 Мөнхүү улиран тохиох дор тийн энэ он төгсөв. Мөн дээрэмчид нэмэгдэж мөн хүчтэй болсоор байв, үүний хэрээр тэд нифайчуудын мөн түүнчлэн леменчүүдийн бүх их

цэргийг эсэргүүцэв; мөн тэд уг нуггийн бүх гадаргуу дээрх хүмүүст агуу айдаас авчрав.

33 Тийм ээ, учир нь тэд уг нуггийн олон хэсэгт зочилж, мөн тэдэнд агуу устгалыг үйлдэв; тийм ээ, олныг алав, мөн бусад заримыг нь, тийм ээ, мөн илүү онцгойлон эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийг нь аглаг буйдад боолчлолд аваачив.

34 Эдүгээ тэдний алдсын нь учир уг хүмүүст ирсэн энэ агуу хилэнц тэднийг Их Эзэн Бурханаа санахад дахин өдөөн хатгав.

35 Мөн шүүгчдийн засаглалын наяннэгдүгээр он тийн төгсөв.

36 Мөн наянхоёрдугаар онд тэд Их Эзэн Бурханаа дахин “мартаж эхлэв. Мөн наянгуравдугаар онд тэд алдаст хүчирхэг болж эхлэв. Мөн наяндөрөвдүгээр онд ч тэд замуудаа өөрчлөн зассангүй.

37 Мөнхүү улиран тохиох дор наянтавдугаар онд тэд бардамналдаа, мөн ёс бус үйлүүдэд улам улам хүчирхэг болж; мөн тэд тийн устгалын тулд дахин боловсорч гүйцэж байв.

38 Мөн наянтавдугаар он тийн төгсөв.

БҮЛЭГ 12

Хүмүүн тогтворгүй мөн мунхаг мөн хилэнцийг хийхдээ түргэн — Их Эзэн хүмүүсээ цээрлүүлдэг — Бурханы хүчтэй харьцуу-

лахад хүмүүн юу ч биш — Шүүлтийн өдөр, хүмүүн үүрдийн амьдралыг эсвэл үүрдийн ялыг авах болно. Ойролцоогоор мээ 6 он.

Мөн хүмүүний үрс ямар хуурамч, мөн түүнчлэн зүрх сэтгэл нь тогтворгүй болохыг бид тийн болгоож чадах буюу; тийм ээ, Их Эзэн өөрт нь “найдлага тавьдаг тэднийг хэмжээлшгүй агуу сайн сайхнаараа адисалж мөн ^бдэгжүүлэхийг бид харж чадна.

2 Тийм ээ, мөн тэрээр өөрийн хүмүүсийг дэгжүүлэх чухам үед, тийм ээ, талбайг нь, бог болон бод малыг нь, мөн алт, мөн мөнгө, мөн бүх төрлийн мөн янз бүрийн уран хийц бүхий үнэт зүйлсийг зүйл бүрээр нь нэмэгдүүлэхэд; амийг нь хэлтрүүлж, мөн тэднийг дайснуудынх нь гараас чөлөөлөхөд; тэдний эсрэг дайн зарлахгүй байлгахын тулд дайснуудынх нь зүрхийг зөөллөхөд; тийм ээ, эцэст нь өөрийн хүмүүсийн сайн сайхан болон аз жаргалын төлөө бүх зүйлийг тэрээр хийхэд; тийм ээ, тэгэхэд тэд зүрх сэтгэлээ “хатууруулж, мөн Их Эзэн Бурханаа мартаж, мөн Ариун Нэгэнийг ^бхөл дороо дэвсэлдэг тийм цаг үе байдгийг бид харж болох бөлгөө —

тийм ээ, мөн энэ нь тэдний амар хөнгөн амьдрал, мөн тэдний үлэмж агуу дэгжлийн учир бөлгөө.

3 Мөн тийн бид Их Эзэн өөрийн хүмүүсийг олон зовлонгоор “цээрлүүлэхгүй бол, тийм ээ, тэр тэдэнд үхлээр мөн аймшгаар, мөн өлсгөлөн болон бүх төрлийн тахлаар зочлохгүй бол, тэд түүнийг ^бсанадаггүйг бид ийн харлаа.

4 Ай ямар мунхаг, мөн ямар хоосон, мөн ямар хилэнцэт, мөн чөтгөр шиг, мөн алдсыг үйлдэхдээ хичнээн “хурдан, мөн сайныг үйлдэхдээ хичнээн удаан билээ, хүмүүний үрс; тийм ээ, хилэнцэт нэгний үгийг сонсохдоо, мөн ^бзүрх сэтгэлээ дэлхийн хоосон зүйлүүд дээр тавихдаа хичнээн хурдан билээ!

5 Тийм ээ, “бардамналд хөөрөхдөө хичнээн хурдан бэ; тийм ээ, сагсуурахдаа, мөн алдас болох түүний бүх төрлийг хийхдээ хичнээн хурдан билээ; мөн Их Эзэн Бурханаа санахдаа, мөн түүний зөвлөмжүүдэд чих тавихдаа хичнээн удаан, тийм ээ, мэргэн ухааны замуудаар ^балхахдаа хичнээн удаан билээ!

6 Болгоогтун, өөрсдийг нь “бүтээсэн Их Эзэн Бурхан нь өөрсдийнх нь дээр ^бзахирахыг мөн засаглахыг тэд хүсдэггүй;

12 1a Дуул. 36:7–8;
2 Ниф. 22:2;
Мозая 4:6.
су Итгэл.
б Шаст. дэд 26:5;
Дуул. 1:2–3.
2a су Урвалт.
б Алма 5:53;

3 Ниф. 28:35.
3a Мозая 23:21;
С ба Г 98:21; 101:8.
б Амос 4:6–11.
4a Ег. 32:8.
б Мат. 15:19; Евр. 3:12.
5a Сур. үгс 29:23.
су Бардамнал.

б су Алхах,
Бурхантай алхах.
6a Иса. 45:9;
С ба Г 58:30;
Моце 7:32–33.
б С ба Г 60:4.

тэдэнд түүний хандуулах агуу сайн сайхан хийгээд нигүүлсэл байсан хэдий ч, тэд түүний зөвлөмжүүдийг үл ойшоодог, мөн тэд түүнийг өөрсдийг нь хөтлөн дагуулагчаа байлгахыг хүсдэггүй.

7 Ай хүмүүний үрс “юу ч биш нь ямар агуу их билээ; тийм ээ, тэд бүр газрын тоосноос ч өчүүхэн билээ.

8 Учир нь болгоогтун, газрын тоос бидний агуу их мөн үүрдийн Бурханы зарлигаар, хоёр хуваагдах хүртлээ нааш цааш хөдөлдөг.

9 Тийм ээ, түүний дуунаар толгод болон уулс доргиж мөн “хөдөлдгийг болгоогтун.

10 Мөн түүний дуу хоолойн “хүчээр тэдгээр нь хагарч, мөн тал болно, тийм ээ, бүр хөндий адил болно.

11 Тийм ээ, түүний дуу хоолойн хүчээр “бүхэл газар сэгсрэгдэх ажгуу;

12 Тийм ээ, түүний дуу хоолойн хүчээр суурь нь, бүр чухамхүү төвдөө хүртэл хөдөлдөг.

13 Тийм ээ, хэрэв тэрээр газарт хандан хэлж—Нүү—гэвэл энэ нь нүүнэ.

14 Тийм ээ, хэрэв тэрээр “дэлхийд хандан хэлж—өдрийг олон цагаар^буртасгахын тул, чи “буцаж яв—гэвэл, энэ нь хийгдсэн байна;

15 Мөн тийн, түүний үгийн

дагуу дэлхий буцаж явна, мөн энэ нь хүмүүнд нар хөдөлгөөнгүй зогсох мэт үзэгдэх бөлгөө; тийм ээ, мөн болгоогтун, энэ нь үүнчлэн байдаг; учир нь нар бус харин дэлхий хөдөлдөг нь гарцаагүй юм.

16 Мөн болгоогтун, түүнчлэн, хэрэв тэрээр агуу их гүний “усанд хэлж—^бчи хат—гэвэл энэ нь хийгдсэн байна.

17 Болгоогтун, хэрэв тэрээр энэ ууланд—чи өргөгд гэвэл, мөн энэ нь булшлагдахын тулд, тэр хотын дээр “ирж мөн унагтун—гэвэл болгоогтун энэ нь хийгдэнэ.

18 Мөн болгоогтун, хэрэв хүн эрдэнэсийг газарт “нуухад, мөн—энэ нь үүнийг нуусан түүний алдсын учир^бзүхэгдэг—хэмээн Их Эзэн хэлбэл болгоогтун, энэ нь зүхэгдэх болно.

19 Мөн хэрэв—энэ цагаас хойш мөн үүрд хэн ч чамайг олохгүй байхын тулд чи зүхэгдэг—хэмээн Их Эзэн хэлбэл, болгоогтун, хэн ч тэр цагаас хойш мөн үүрд үүнийг авахгүй.

20 Мөн болгоогтун, хэрэв—Алдсуудын учир, чи үүрд зүхэгдэх болно—хэмээн Их Эзэн хүнд хэлбэл энэ нь хийгдэх болно.

21 Мөн хэрэв—Алдсуудынхаа учир чи дэргэдээс минь тусгаарлагдах болно—хэмээн

7a Иса. 40:15, 17;

Мозая 4:19;

Моце 1:10.

9a 3 Ниф. 22:10.

10a 1 Ниф. 17:46.

11a Морм. 5:23;

Ифер 4:9.

14a Иош. 10:12–14.

б Хаад. дэд 20:8–11.

в Иса. 38:7–8.

16a Мат. 8:27.

б Иса. 44:27; 51:10.

17a 3 Ниф. 8:10.

18a Морм. 1:18;

Ифер 14:1.

б Хил. 13:17.

Их Эзэн хэлбэл тэрээр үүнийг түүнчлэн байхаар болгох болно.

22 Тэрээр үүнийг хэнд хэлнэв, түүнд халаг байна, учир нь алдсыг үйлдэх түүнд л байх болно, мөн тэрээр аврагдаж чадахгүй; тиймийн тул, хүмүүн аврагдаж болох энэхүү шалтгааны учир, наманчлал тунхаглагдсан юм.

23 Тиймийн тул, наманчлах мөн Их Эзэн Бурханыхаа дуу хоолойг анхааран сонсдог тэд адислагдсан байдаг; учир нь тэд бол “аврагдах тэд билээ.

24 Мөн хүмүүн наманчлалд хийгээд сайн ажлуудад авчрагдаж болохыг, тэд үйлүүдийнхээ дагуу ач ивээлийн тулд “ач ивээлд сэргээгдэж болохыг Бурхан агуу их бүрэн байдлаараа соёрхох болтугай.

25 Мөн бүх хүмүүн аврагдах болоосой хэмээнэ би. Гэвч бидний уншдагчлан агуу их хийгээд эцсийн өдөр зайлуулагдах, тийм ээ, Их Эзэний дэргэдээс тусгаарлагдах зарим нь байх болно;

26 Тийм ээ, төгсгөлгүй аймшгийн байдалд хүргэгдэх тэд энэхүү үгсийг гүйцэлдүүлэх болно: Сайныг хийсэн нь “үүрдийн амьдралыг авах болно; мөн хилэнцийг хийсэн нь үүрдийн “ял авах болно. Мөн энэ нь тийн болой. Амен.

Нифайчуудад хандсан лемен үндэстэн Самуелын бошиглол оршвой.

13-аас 15 дугаар бүлэгт агуулагдсав.

БҮЛЭГ 13

Нифайчууд наманчлахгүй бөгөөс тэд устгагдаж болохыг лемен үндэстэн Самуел бошиглов— Тэд мөн тэдний баялгууд зүхэгдэв— Тэд бошиглогчдыг эсэргүүцэж мөн чулуугаар шидэж, чөтгөрүүдээр хүрээлэгдэн, мөн алдсыг үйлдэж аз жаргалыг эрэлхийлэв. Ойролцоогоор мээ 6 он.

Мөнхүү эдүгээ улиран тохиох дор наян зургадугаар онд “леменчүүд Мосегийн хуулийн дагуу, Бурханы зарлигуудыг дагахаар чандлан хичээж байх үед, нифайчууд ёс бус үйлүүддээ, тийм ээ, агуу ёс бус үйлэнд хэвээр үлдэв, бөлгөө.

2 Мөнхүү улиран тохиох дор энэхүү онд лемен үндэстэн Самуел гэгч нэгэн, Зарахемла нутагт ирж, мөн хүмүүст номлож эхлэв. Мөнхүү улиран тохиох дор тэрээр, хүмүүст наманчлалыг олон өдөр номлож, мөн тэд түүнийг хөөж гарган, мөн тэрээр нутагтаа буцах гэж байв.

3 Гэвч болгоогтун, Их Эзэний дуу хоолой түүнд ирж, түүнийг дахин эргэн очиж, мөн “зүрх сэтгэлд нь ирэх аливаа зүйлийг хүмүүст бошиглохыг хэлэв.

4 Мөнхүү улиран тохиох дор тэд түүнийг хотод орохыг зөвшөөрсөнгүй; тиймийн тул

23a су Аврал.
24a су Ач ивээл.
26a Мат. 25:46;

Иохан 5:28–29;
Ром 6:13.
б су Ял.

13 1a Хил. 15:4–5.
3a С ба Г 100:5.

тэрээр явж мөн үүний хэр-
мэн дээр гарч, мөн гараа
дэлгэн мөн чанга дуугаар
хашгирч, мөн Их Эзэн зүрх
сэтгэлд нь өгсөн аливаа зүй-
лийг хүмүүст бошиглов.

5 Мөн тэрээр тэдэнд хэлэв:
Болгоогтун, би, Самуел, ле-
мен үндэстэн, Их Эзэн зүрх
сэтгэлд минь өгсөн түүний
үгсийг ярья; мөн болгоогтун
тэрээр шударга ёсны “илд
энэ хүмүүсийн дээр далай-
гаастай байгааг энэ хүмүүст
хэлэхийг зүрх сэтгэлд минь
өглөө; мөн шударга ёсны
илд энэ хүмүүсийн дээр буух
хүртэл дөрвөн зуун жил ули-
ран одохгүй бөлгөө.

6 Тийм ээ, дэлхийд гарцаа-
гүй ирэх, мөн энэ хүмүүсийн
төлөө олон зүйлийг тэвчиж
мөн егүүтгэгдэх, Их Эзэн Есүс
Христэд итгэх итгэл мөн
наманчлалаас өөр юу ч энэ
хүмүүсийг аварч чадахгүй,
мөн энэ хүмүүсийг хүнд бэрх
“устгал хүлээж байна, мөн
энэ нь энэ хүмүүсийн дээр
гарцаагүй ирэх болно.

7 Мөн болгоогтун, Их Эзэн-
ний нэгэн “тэнгэр элч надад
үүнийг тунхаглаж, мөн тэр-
рээр бодгальд минь “баярт
мэдээ авчирсан болой. Мөн
болгоогтун, та нарт ч баярт
мэдээ байж болохын тулд
үүнийг та нарт түүнчлэн тун-
хаглахаар илгээгдсэн болой
би; гэвч болгоогтун та нар
намайг хүлээн авсангүй.

8 Тиймийн тул, Их Эзэн
ийн хэлэв: Тэд наманчлахгүй
аваас нифайчуудын ард
түмний зүрх сэтгэл хатуу-
гийн учир, би өөрийн үгийг
тэднээс татан авна, мөн
би Сүнсээ тэднээс “буцааж
авах болно, мөн би тэднийг
цаашид тэвчихгүй, мөн ах
дүүсийнх нь зүрх сэтгэ-
лийг тэдний эсрэг эргүүлэх
болно би.

9 Мөн би тэднийг цохигдо-
хоор болгохоос өмнө “дөрвөн
зуун жил улиран өнгөрөхгүй;
тийм ээ, би тэдэнд илдээр
мөн өлсгөлөнгөөр мөн тах-
лаар зочлох болно.

10 Тийм ээ, би тэдэнд дог-
шин уур хилэнгээрээ зочлох
болно, мөн дайснуудын чинь
дөрөв дэх үеийнхнээс та на-
рын бүрмөсөн устгалыг бол-
гоохоор амьд үлдэх тэд байх
болно; мөн та нар наманч-
лахгүй аваас гарцаагүй ирэх
болно хэмээн Их Эзэн хэлсэн
билээ; мөн “дөрөв дэх үеийнх-
ний тэд та нарт устгалаар
зочлох болно.

11 Гэвч та нар наманчилж
мөн Их Эзэн Бурхандаа “хан-
дах аваас, би уур хилэнгээ
зайлуулах болно хэмээн Их
Эзэн хэлдэг; тийм ээ, наманч-
лах мөн надад хандах тэд
адислагдсан болой, харин на-
манчлахгүй түүнд халаг байх
болно хэмээн Их Эзэн тийн
хэлдэг.

12 Тийм ээ, энэ агуу хот

5a Алма 60:29;
3 Ниф. 2:19.
6a Алма 45:10–14;
Хил. 15:17.

7a Алма 13:26.
б Иса. 52:7.
8a Хил. 6:35.
9a Алма 45:10–12.

10a 1 Ниф. 12:12;
2 Ниф. 26:9;
3 Ниф. 27:32.
11a 3 Ниф. 10:5–7.

Зарахемлад “халаг; учир нь болгоогтун, үүний аврагдаж байгаа нь зөв шударгыг үйлдэгсэд тэдний улмаас юм; тийм ээ, энэ агуу хотод халаг, учир нь Их Эзэн хэлнэ, миний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулах нь олон байгаа, тийм ээ, энэ агуу хотын бүр ихэнх хэсэг нь болохыг би ухамсарлана хэмээн Их Эзэн хэлж байна.

13 Гэвч наманчлах тэд адислагдсан болой, учир нь тэднийг би хэлтрүүлэх болно. Гэвч болгоогтун, хэрэв энэ агуу хотод зөв шударгыг үйлдэгсэд байгаагүй аваас, болгоогтун, би тэнгэрээс доош “гал буулган мөн үүнийг устгахаар болгох сон.

14 Гэвч болгоогтун, үүний хэлтрүүлэгдэж байгаа нь зөв шударгыг үйлдэгсдийн төлөө болой. Гэвч болгоогтун, та нарын дундаас зөв шударгыг үйлдэгчдийг зайлуулах тэр үед, тэгээд та нар устгалын тулд боловсорч гүйцсэн байх тэр цаг ирэх болно хэмээн Их Эзэн хэлэв; тийм ээ, үүн дэх ёс бус үйлүүд мөн жигшүүрт хэргүүдийн учир, энэ агуу хотод халаг болог.

15 Тийм ээ, үүний доторх ёс бус үйлүүд мөн жигшүүрт хэргүүдийн учир мөн Гидеон хотод халаг болог.

16 Тийм ээ, мөн тэдний доторх ёс бус үйлүүд мөн жигшүүрт хэргүүдийн учир, нифайчуудаар эзэмшигдсэн,

эргэн тойрны нутаг дахь тэр бүх хотуудад халаг болог.

17 Мөн болгоогтун, Түмний Их Эзэн хэлэв, уг нутагт буй хүмүүсээс болж, тийм ээ, тэдний ёс бус үйлүүд мөн тэдний жигшүүрт хэргүүдийн учир “зүхэл уг нутгийн дээр ирэх болно.

18 Мөнхүү улиран тохиох дор, Түмний Их Эзэн, тийм ээ, агуу их болоод үнэн Бурхан маань хэлдэг, тэр нь зөв шударга хүн байж мөн үүнийг Их Эзэний төлөө нуухаас бусдаар эрдэнэсийг газарт “нуусан хэн боловч, уг нутгийн агуу их зүхлийн учир тэдгээрийг дахин хэзээ ч олохгүй.

19 Учир нь Их Эзэн хэлдэг, тэд эрдэнэсээ миний төлөө нуугаасай хэмээн хүснэ би; мөн эрдэнэсээ миний төлөө нуугаагүй тэд зүхэгдэх болно; учир нь зөв шударгыг үйлдэгсдээс бусад хэн ч миний төлөө эрдэнэсээ нуудаггүй; мөн эрдэнэсээ миний төлөө нуухгүй түүнд, мөн түүнчлэн уг эрдэнэс нь зүхэгдсэн, уг нутгийн зүхлийн учир юу ч үүнийг гэтэлгэхгүй.

20 Мөн тэд зүрх сэтгэлээ баялгууд дээр тавьсан учир, эрдэнэсээ нуух тэр өдөр ирэх болно; мөн тэд зүрх сэтгэлээ баялгуудынхаа дээр тавьсан учир тэд дайснуудынхаа өмнө зугтах үедээ эрдэнэсээ нуух болно; тэд тэдгээрийг миний төлөө нуухгүй учраас,

12a 3 Ниф. 8:8, 24; 9:3.

13a Эхл. 19:24;

Хаад. дэд 1:9–16;

3 Ниф. 9:11.

17a Хил. 12:18.

18a Морм. 1:18;

Ифер 14:1.

тэд мөн түүнчлэн тэдний эрдэнэс нь ч зүхэгдэг; мөн тэрхүү өдөр тэд цохигдох болно хэмээн Их Эзэн хэлж байна.

21 Болгоогтун энэ агуу хотын хүмүүс та нар, мөн үгсийг минь “анхааран сонсооч; тийм ээ, Их Эзэний хэлэх үгсийг анхааран сонсоцгоо; учир нь болгоогтун, та нар баялгуудынхаа учир зүхэгдсэн, мөн түүнчлэн та нар зүрх сэтгэлээ тэдгээрийн дээр тавьсан учир, мөн тэдгээрийг та нарт өгсөн түүний үгсийг анхааран сонсоогүй учир баялгууд чинь ч зүхэгдсэн билээ.

22 Тэрээр та нарыг адисалсан зүйлүүдэд та нар Их Эзэн Бурханаа санадаггүй, гэвч та нар “баялгуудаа үргэлж санаж байдаг, тэдгээрийн төлөө Их Эзэн Бурхандаа талархахын тулд ч бус юм; тийм ээ, та нарын зүрх сэтгэл Их Эзэнд хандахгүй байгаа, харин тэдгээр нь сайрхалд, мөн агуу хөөрөлд, ⁶атаа жөтөө, хэрүүл маргаан, өшөө хорсол, хавчлага гадуурхал, мөн алагууд, мөн бүх төрлийн алдсуудад хүртлээ агуу “бардамналд тэлдэг болой.

23 Энэ шалтгааны учир Их Эзэн Бурхан зүхлийг уг нутгийн дээр, мөн түүнчлэн та нарын баялгууд дээр ирэх болгосон буюу, мөн энэ нь та нарын алдсуудын учир болой.

24 Тийм ээ, бүр хуучин цагийн тэдний хийдэг байсны адилаар та нар бошиглогчдыг “зайлуулж, мөн тэднийг элэглэн, мөн тэдний зүг чулуу шидэж, мөн тэднийг хөнөөж, мөн тэдэнд бүх төрлийн алдсыг үйлдэх болсон энэ цагийн учир энэ хүмүүст халаг.

25 Мөн эдүгээ та нар ярихдаа: хэрэв бидний өдрүүд хуучны “эцэг өвгөдийн минь өдрүүдэд байсан бол, бид бошиглогчдыг алахгүй байсан; бид тэдний зүг чулуу шидэж, мөн тэднийг зайлуулахгүй байсан хэмээн та нар хэлдэг.

26 Болгоогтун та нар тэднээс ч дор; учир нь Их Эзэн амьдын адил, хэрэв та нарын дунд “бошиглогч ирж мөн та нарын нүглүүд хийгээд алдсуудыг гэрчилсэн, Их Эзэний үгийг та нарт тунхаглах аваас, та нар түүнд ⁶уурлаж, мөн түүнийг зайлуулж мөн түүнийг устгах бүх төрлийн арга замуудыг эрэлхийлдэг; тийм ээ, тэрээр та нарын үйлүүдийг хилэнцэт хэмээн ⁶гэрчилдэг учир та нар тэр бол хуурамч ⁶бошиглогч, мөн тэр бол нүгэлтэн, мөн чөтгөрийнх хэмээн хэлэх болно.

27 Гэвч болгоогтун, хэрэв нэгэн хүн та нарын дунд ирж: Үүнийг хий, мөн алдас гэж үгүй; түүнийг үйлд мөн та нар зовох нь үгүй гэж хэлбэл;

21а су Сонсох.

22а Лук 12:34.

су Баялгууд;

Дэлхийнх.

б су Атаархал.

в су Бардамнал.

24а Шаст. дэд 36:15–16;

1 Ниф. 1:20.

25а Үйлс 7:51.

26а Шаст. дэд 18:7;

Лук 16:31.

б Иса. 30:9–10.

в Гал. 4:16.

г Мат. 13:57.

тийм ээ: Зүрх сэтгэлдээ бардамналтайгаар алх; тийм ээ, харцандаа бардамналтайгаар алх, мөн зүрх сэтгэлийнхээ хүссэн юуг ч боловч үйлд гэж тэр хэлбэл — мөн хэрэв нэгэн хүн та нарын дунд ирж үүнийг хэлбэл, та нар түүнийг хүлээн авч, мөн түүнийг “бошиглогч гэж хэлэх болно.

28 Тийм ээ, та нар түүнийг өргөмжлөх болно, мөн та нар түүнд хөрөнгөнөөсөө өгөх болно; та нар түүнд алтнаасаа, мөн мөнгөнөөсөө өгөх болно, мөн та нар түүнийг үнэт хувцас хунараар хувцаслах болно; мөн тэрээр “зусарч үгсийг та нарт ярина, мөн бүгд зүгээр гэж хэлэх учир, тийнхүү та нар түүнээс бурууг олохгүй байх болно.

29 Ай ёс бус та нар мөн тэрслүүд үеийнхэн та нар; хатуурхсан та нар мөн зөрүүд хүмүүс та нар, Их Эзэн та нарыг хэр удаан тэвчинэ гэж та нар бодож байна? Тийм ээ, та нар өөрсдийгөө “мунхаг мөн ^бхаралган удирдагчдаар дагуулагдахыг хэр удаан тэвчих билээ? Тийм ээ, та нар “гэрлээс илүүтэйгээр харанхуйг хэр удаан ‘сонгох билээ?

30 Тийм ээ, болгоогтун, Их Эзэний уур хилэн аль хэдийн та нарын эсрэг шатаж байна; болгоогтун, тэрээр уг нутгийг алдсын чинь учир зүхсэн билээ.

31 Мөн болгоогтун, тэдгээр

нь “гулгамтгай болсноос та нар тэдгээрийг барьж байж чадахгүйн улмаас, тэрээр баялгуудыг чинь зүхэх тэр цаг ирэх болно; мөн ядуурлынхаа өдрүүдэд та нар тэдгээрийг хадгалан үлдээж чадахгүй.

32 Мөн ядуурлынхаа өдрүүдэд та нар Их Эзэнд гуйн залбирах болно; мөн та нар хоосон залбиран гуйх болно, учир нь хоосрол тань аль хэдийн та нарын дээр ирнэ, мөн устгал тань гарцаагүй хийгдэх болно; мөн тэгээд тэр өдөр та нар уйлж мөн гаслах болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг. Мөн тэгэхэд та нар гашуудах болно, мөн өгүүлэн:

33 Ай “би наманчилсан болоосой мөн бошиглогчдыг алаагүй, тэдний зүг ^бчулуу шидээгүй, мөн тэднийг зайлуулаагүй болоосой. Тийм ээ, тэр өдөр та нар хэлэх болно: Ай тэрээр баялгуудыг маань өгсөн тэр өдөр Их Эзэн Бурханаа бид санасан ч болоосой, мөн тэгээд гулгамтгай болсноос бид тэдгээрийг алдахгүйсэн; учир нь болгоогтун, баялгууд маань биднээс үгүй болжээ.

34 Болгоогтун, бид багажаа энд тавихад мөн маргааш нь энэ нь үгүй болсон байна; мөн болгоогтун, илднүүд маань бид тулалдахын тулд тэдгээрийг эрэлхийлсэн тэр өдөр биднээс авагдсан байна.

27a Мика 2:11.
су Санваараар
мэргэшэх.
28a 2 Тим. 4:3–4.

29a 2 Ниф. 28:9.
б Мат. 15:14.
в Иов 24:13.
г Иохан 3:19.

31a Морм. 1:17–18.
33a Морм. 2:10–15.
б Мат. 23:37.

35 Тийм ээ, уг нутгийн зүхлийн учир, бид эрдэнэсээ нуугаад мөн тэдгээр нь биднээс гулган зайлав.

36 Ай Их Эзэний үг бидэнд ирсэн тэр өдөр бид наманчилсан ч болоосой; учир нь болгоогтун уг нутаг зүхэгдсэн, мөн бүх зүйл гулгамтгай болж, мөн бид тэдгээрийг барьж чадахгүй болов.

37 Болгоогтун, бид чөтгөрүүдээр хүрээлэгдсэн, тийм ээ, бодгалиудыг маань устгахыг эрэлхийлэх түүний элчүүдээр бид бүслэгдэв. Болгоогтун, алдсууд маань агуу их. Ай Их Эзэн, та уур хилэнгээ биднээс зайлуулж болохгүй юу? Мөн энэ нь тэр өдрүүдэд та нарын өгүүлэх зүйл байх болно.

38 Гэвч болгоогтун, сорилтын чинь “өдрүүд өнгөрсөн; та нар авралынхаа өдрийг энэ нь бүрмөсөн дэндүү оройтох хүртэл ^бхойшлуулсан, мөн устгал чинь гарцаагүй болсон билээ; тийм ээ, учир нь та нар амьдралынхаа бүх өдрүүдэд хүрч чадахгүй түүнийг эрэлхийлсэн; мөн та нар алдсыг үйлдэж “аз жаргалыг эрэлхийлсэн нь бидний агуу их Мөнхийн Тэргүүнд байх зөв шударга чанарын эсрэг юм.

39 Ай уг нутгийн хүмүүс та нар, үгсийг минь сонсоосой! Мөн Их Эзэний уур хилэн та нараас зайлуулагдаж, мөн та нар наманчилж мөн аврагдаасай хэмээн залбирна би.

БҮЛЭГ 14

Христийг төрөхөд шөнийн турш гэрэл мөн шинэ од үзэгдэхийг угтан хэлэв—Христ хүмүүнийг биеийн болон сүнсний үхлээс гэтэлгэдэг—Түүний үхлийн тэмдгүүд нь гурван өдрийн харанхуйлал, хад хагарах, мөн байгалийн агуу гамигуудыг хамрах болно. Ойролцоогоор мээ 6 он.

Мөнхүү эдүгээ улиран тохиох дор лемен үндэстэн тэрхүү “Самуел , бичигдэх аргагүй илүү олон агуу зүйлийг бошиглов.

2 Мөн болгоогтун, тэрээр тэдэнд хэлэв: Болгоогтун, би та нарт тэмдэг өгье; учир нь дахин таван жил өнгөрөхөд, мөн болгоогтун, тэгэхэд Бурханы Хүү өөрийнх нь нэрэнд итгэх тэд бүгдийг гэтэлгэхээр ирэх болно.

3 Мөн болгоогтун, түүний ирэлтийн үеийн “тэмдэг болгон би үүнийг та нарт өгөх болно; учир нь болгоогтун, тэнгэрт агуу гэрлүүд байх болно, үүний хэрээр түүнийг ирэхийн өмнөх шөнө харанхуй болохгүй, үүний хэрээр энэ нь хүмүүнд өдөр мэт үзэгдэх болно.

4 Тиймийн тул, нэг өдөр мөн шөнө мөн өдөр, шөнөгүй нэгэн өдөр лугаа адил байх болно; мөн энэ нь та нарт тэмдэг байх болно; учир нь та нар нар ургахыг мөн түүнчлэн шингэхийг нь мэдэх

болно; тиймийн тул тэд хоёр өдөр мөн нэг шөнө болохыг гарцаагүй мэдэх болно; гэсэн хэдий ч шөнө нь харанхуйлахгүй; мөн энэ нь “түүний төрөхийн өмнөх шөнө байх болно.

5 Мөн болгоогтун, та нарын хэзээ ч тийм нэгнийг болгоогүй тэрхүү нэгэн шинэ “од гарах болно; мөн энэ нь түүнчлэн та нарт тэмдэг байх болно.

6 Мөн болгоогтун энэ нь бүгд бус, тэнгэрт олон тэмдэг мөн гайхамшгууд байх болно.

7 Мөнхүү улиран тохиох дор та нар бүгд бахдаж мөн гайхах болно, үүний хэрээр та нар газарт “унах болно.

8 Мөнхүү улиран тохиох дор Бурханы Хүүд “итгэх хэн боловч, мөнхүү тэр нь үүрдийн амьдралыг авах болно.

9 Мөн болгоогтун, намайг ирж мөн энэ зүйлийг та нарт хэлэх ёстой хэмээн, Их Эзэн өөрийн тэнгэр элчээр надад ийн зарлигласан билээ; тийм ээ, тэрээр эдгээр зүйлийг намайг та нарт бошиглохыг зарлигласан болой; тийм ээ, тэрээр надад: Энэ хүмүүст наманчилж мөн Их Эзэний замыг бэлтгэ хэмээн хашгир гэсэн билээ.

10 Мөн эдүгээ, би лемен үндэстэн, мөн Их Эзэний надад зарлигласан үгсийг та нарт ярьсан учир, мөн энэ нь та

нарын эсрэг хатуу байсан учир, та нар надад уурлаж мөн намайг устгахаар эрэлхийлж байна, мөн өөрсдийн дундаас намайг “хөөн зайлуулсан болой.

11 Мөн та нар үгсийг сонсох миний болно, учир нь, энэ зорилгын тулд би энэ хотын хэрмэн дээр гарсан, алдсуудын чинь учир та нарыг хүлээх Бурханы шүүлтийн талаар та нар сонсож мөн мэдэж болохын тулд, мөн түүнчлэн та нар наманчлалын нөхцөлийг мэдэж болохын тулд болой.

12 Мөн түүнчлэн эхлэлээс бүх зүйлийг Бүтээгч, тэнгэрийн болон газрын “Эцэг, Бурханы Хүү, Есүс Христийн ирэлтийн тухай та нар мэдэж болохын тулд; мөн та нар түүний нэрэнд итгэж болох тэрхүү зорилгын тулд та нар түүний ирэлтийн тэмдгүүдийн талаар мэдэж болохын тулд бөлгөө.

13 Мөн хэрэв та нар түүний нэрэнд “итгэвэл бүх нүглүүдээ наманчилж, тэгснээр та нар тэдгээрийн ангижралыг түүний ^бсайн үйлээр дамжуулан олж болно.

14 Мөн болгоогтун, тэрчлэн, бас нэг тэмдэг, тийм ээ, түүний үхлийн тэмдгийг би та нарт өгье.

15 Учир нь болгоогтун, “аврал ирж болохын тулд тэрээр

4a су Есүс Христ—
Есүс Христийн
төрөлт болон нас
баралтын тухай
бошиглол.
5a Мат. 2:1–2;

3 Ниф. 1:21.
7a 3 Ниф. 1:16–17.
8a Иохан 3:16.
10a Хил. 13:2.
12a Мозая 3:8;
3 Ниф. 9:15;

Ифер 4:7.
су Есүс Христ.
13a Үйлс 16:30–31.
б С ба Г 19:16–20.
15a су Аврагч.

гарцаагүй үхэх ёстой; тийм ээ, хүмүүн Их Эзэний дэргэд авчрагдаж болохын тулд, нас барагсдын ⁶амилуулалт улиран тохиоход түүний үхэх нь түүнд зохих ёсны хийгээд зайлшгүй зүйл билээ.

16 Тийм ээ, болгоогтун, энэ үхэл амилуулалтыг улируулан тохиолгож, мөн эхний үхлээс — сүнсний үхлээс бүх хүн төрөлхтнийг ⁴гэтэлгэнэ; учир нь бүх хүн төрөлхтөн, Адамын ⁶уналтаар Их Эзэний дэргэдээс ⁴тусгаарлагдсан учир, биеийн зүйлүүд мөн сүнсний зүйлүүдийн аль алинаар нь ¹үхмэлд тооцогдсон бөлгөө.

17 Гэвч болгоогтун, Христийн амилалт хүн төрөлхтнийг, тийм ээ, бүр бүх хүн төрөлхтнийг ⁴гэтэлгэнэ, мөн тэднийг Их Эзэний дэргэд буцааж авчрах болно.

18 Тийм ээ, наманчлалын нөхцөлийг хангаснаас, наманчлах хэн боловч тэр нь тас цавчигдаж мөн галд хаягдахгүй; харин наманчлахгүй хэн боловч тас цавчигдаж мөн галд хаягдах болно; мөн тэдний дээр сүнсний үхэл дахин ирнэ, тийм ээ, хоёр дахь үхэл, учир нь тэд зөв шударгад хамаарагдах зүйлүүдийн хувьд дахин тусгаарлагдах болно.

19 Тиймийн тул наманчлагтун та нар, наманчлагтун та нар, эдгээр зүйлийг мэдээд

мөн эдгээрийг хийхгүй байснаар та нар өөрсдөө буруушаагдахыг хүлцдэг, мөн энэ хоёр дахь үхэлд та нар доош хүргэгдэх болуузай.

20 Гэвч болгоогтун, өөр нэг ⁴тэмдэг, түүний үхлийн тэмдгийн талаар та нарт миний хэлсэнчлэн, болгоогтун, тэрвээр үхлийг амсах тэр өдөр нар мөн түүнчлэн сар болон олол ⁶харанхуйлагдаж мөн гэрлээ та нарт өгөхөөс татгалзана; мөн энэ нутгийн гадаргуу дээр, бүр тэрээр үхлийг амсах тэр үеэс, ⁴гурван хоногийн турш, нас барагсдын дундаас түүний босох тэр цагийг хүртэл гэрэл байхгүй байх болно.

21 Тийм ээ, тэрбээр сүнсээ чөлөөлөх тэр үед олон цагийн турш аянга мөн ⁴цахилгаан цахиж, мөн газар доргиж мөн чичрэх болно; мөн энэ газрын гадаргуу дээрх хад чулуу, газар дээр ч мөн доор ч аль аль нь, та нарын одоо цул, эсвээс цул биеийн нэг хэсэг хэмээн мэдэх тэдгээр нь хагарч ⁶бутрах болно;

22 Тийм ээ, тэдгээр нь хуваагдан цуурч, мөн үүнээс хойш хагархай мөн цуурхай байх болно, мөн бүхэл газрын гадаргуу дээр хагарсан хэлтэрхийнүүд, тийм ээ, газрын дээр мөн доор аль алинд нь ⁴байх болно.

23 Мөн болгоогтун, аймшигт

15б Алма 42:23.
су Амилуулалт.

16а су Гэтэлгэлийн
төлөвлөгөө.
б су Адам Ева хоёрын
Уналт.

в Алма 42:6–9.
г су Сүнсний үхэл.
17а су Гэтэлгэх,
Гэтэлгэгдэх,
Гэтэлгэл.
20а 3 Ниф. 8:5–25.

б Лук 23:44.
в Мозая 3:10.
21а 3 Ниф. 8:6.
б 3 Ниф. 10:9.
22а 3 Ниф. 8:18.

догшин шуурга болно, мөн олон уулс хөндий болтлоо нурсан байна, мөн одоо хөндий гэж нэрлэгдэж байгаа ч агуу өндөр уулс болох олон газар байх болно.

24 Мөн олон дардан зам эвдэрсэн байна, мөн олон “хот эзгүй болсон байх болно.

25 Мөн олон булш “нээгдэж, мөн тэдгээр нь үхэгсдийнхээ олныг нь чөлөөлөх болно; мөн олон гэгээнтэн олонд үзэгдэх болно.

26 Мөн болгоогтун, “тэнгэр элч надад тийн ярьсан билээ; учир нь олон цагийн турш аянга мөн цахилгаан цахих болно хэмээн тэрээр надад хэлсэн.

27 Мөн аянга болон цахилгаан, мөн догшин шуурга үргэлжилж байх үед, эдгээр зүйл байх болно, мөн бүхэл газрын гадаргууг гурав хоногийн турш “харанхуй бүрхэх болно хэмээн тэрээр надад хэлсэн бөлгөө.

28 Мөн “эдгээр тэмдгүүд мөн эдгээр гайхамшгууд энэ нутгийн бүх гадаргуу дээр улиран тохиох болно гэдэгт тэд итгэж болох зорилгын тулд, хүмүүний үрсийн дунд итгэлгүйн ямар ч шалтгааныг байлгахгүй хэмээх зорилгын тулд олон нь эдгээрээс илүү агуу зүйлсийг харна, хэмээн тэнгэр элч надад хэлэв—

29 Мөн энэ нь, итгэх хэн боловч аврагдаж болно, мөн итгэхгүй хэн боловч, зөв шударгын шударга “шүүлт тэдний дээр ирж болох зорилгын тулд болой; мөн түүнчлэн хэрэв тэд буруушаагдвал тэд өөрсдийн дээр буруушаалтыг авчрах бөлгөө.

30 Мөн эдүгээ санагтун, санагтун, ах дүүс минь, мөхөх хэн боловч, өөртөө мөхөх буюу; мөн алдсыг үйлдэх хэн боловч, үүнийг өөртөө үйлдэх буюу; учир нь болгоогтун, та нар “чөлөөтэй; өөрсдийнхөө төлөө үйлдэх нь та нарт зөвшөөрөгдсөн билээ; учир нь болгоогтун, Бурхан та нарт ^бмэдлэг өгч мөн тэрээр та нарыг чөлөөтэй болгосон буюу.

31 Та нар хилэнцээс сайныг “мэдэж болохын тулд тэрээр та нарт өгсөн, мөн та нар амьдрал эсвэл үхлийг ^бсонгож болохын тулд тэрээр та нарт өгсөн билээ; мөн та нар сайныг хийж мөн сайн болох түүнд “сэргээгдэж, өөрөөр хэлбэл сайн болох тэр нь та нарт сэргээгдэж болох бөлгөө; эсвээс та нар хилэнцийг хийж, мөн хилэнцэт болох тэр нь та нарт сэргээгдэж болох бөлгөө.

БҮЛЭГ 15

Их Эзэн нифайчуудыг хайрласан

24a 3 Ниф. 9:3–12.
25a Мат. 27:50–54;
3 Ниф. 23:9–11.
26a Алма 13:26.
27a 1 Ниф. 19:10;
3 Ниф. 8:3.

28a 1 Ниф. 12:4–5.
29a су Эцсийн шүүлт.
30a 2 Ниф. 2:26–29;
Мосе 6:56.
су Сонгох эрх.
б су Мэдлэг.

31a Моро. 7:16.
б 2 Ниф. 2:28–29;
Алма 3:26–27.
в Алма 41:3–5.

учраас тэр тэднийг цээрлүүлэв — Хөрвүүлэгдсэн леменчүүд сүсэг бишрэлдээ чанд мөн гуйвшгүй байв — Их Эзэн хожмын өдрүүдэд леменчүүдэд нигүүлсэнгүй байх болно. Ойролцоогоор мээ 6 он.

Мөн эдүгээ, хайрт ах дүүс минь, болгоогтун, та нар наманчлахгүй аваас гэр орон чинь “хоосрон орхигдох болно гэдгийг би та нарт тунхаглана.

2 Тийм ээ, та нар наманчлахгүй аваас, эмэгтэйчүүд чинь хөхүүлж байх өдрөө гашуудах агуу шалтгаантай байх болно; учир нь зугтахаар завдахад мөн орогнох газар та нарт үгүй байх болно; тийм ээ, мөн “хүүхдээ тээсэн тэдэнд халаг байна, учир нь тэд хөл хүнд мөн зугтаж чадахгүй байх болно; тиймийн тул, тэд доор дэвслэгдэж мөн мөхөхөөр орхигдох болно.

3 Тийм ээ, тэдэнд үзүүлэгдэх эдгээр бүх тэмдгүүд мөн гайхамшгуудыг тэд харна, тэд наманчлахгүй аваас Нифайн хүмүүс гэж нэрлэгдсэн энэ хүмүүст халаг; учир нь болгоогтун, тэд Их Эзэнээр сонгогдсон нэгэн ард түмэн байсаар буй; тийм ээ, Нифайн хүмүүсийг тэр хайрласан, мөн түүнчлэн тэднийг “цээрлүүлсэн; тийм ээ, тэр тэднийг хайрладаг учраас алдсуудынх нь өдрүүдэд тэднийг цээрлүүлсэн билээ.

4 Гэвч болгоогтун ах дүүс минь, үйлүүд нь үргэлжийн хилэнцэт байсан учир тэрээр леменчүүдийг үзэн ядав, мөн энэ нь тэдний эцэг өвгөдийнх нь “уламжлалын алдсын учир билээ. Гэвч болгоогтун, нифайчуудын номлолоор аврал тэдэнд ирсэн бөлгөө; мөн энэ зорилгын тулд Их Эзэн тэдний өдрүүдийг “уртасгасан болой.

5 Мөн тэдний “ихэнх хэсэг нь үүргийнхээ замд байж, мөн тэд Бурханы өмнө хянамгай алхаж, мөн тэд Мосегийн хуулийн дагуу түүний зарлигуудыг мөн түүний дүрмүүд хийгээд тогтоолуудыг дагахаар чармайна гэдгийг та нар болгоогоосой хэмээнэ би.

6 Тийм ээ, би та нарт хэлнэ, тэдний ихэнх хэсэг нь үүнийг хийж, мөн тэд ах дүүсийнхээ үлдсэнийг нь үнэний мэдлэгт авчирч болохын тулд тэд шантралгүй хичээнгүйлэн оролдож байна; тиймийн тул өдөр тутам тэдний тоог нэмж байгаа нь олон байна.

7 Мөн болгоогтун, та нар өөрсдөө мэднэ, учир нь та нар үүнийг гэрчилсэн, үнэний мэдлэгт мөн эцэг өвгөдийнхөө ёс бус мөн жигшүүрт уламжлалын тухай мэдэхээр авчрагдсан болгон нь, мөн тэдэнд зүрх сэтгэлийн “өөрчлөлтийг авчрах тэрхүү итгэл хийгээд наманчлал болох Их Эзэнд итгэх итгэлд мөн

15 1a Мат. 23:37–38.

2a Мат. 24:19.

3a Сур. үгс 3:12;

Евр. 12:5–11;

С ба Г 95:1.

4a су Уламжлалууд.

б Алма 9:16.

5a Хил. 13:1.

7a су Хөрвүүлэг,

Хөрвөгч.

наманчлал тийш удирдах ариун судруудад, тийм ээ, ариун бошиглогчдын бичсэн бошиглолуудад итгэхээр удирдагдсан болгон нь—

8 Тиймийн тул, үүнд ирсэн болгон нь, сүсэг бишрэлдээ, мөн тэд юугаар чөлөөтэй болгогдсон түүндээ “чанд гуйвшгүй байгааг та нар өөрсдөө мэднэ.

9 Мөн түүнчлэн тэд дайны ээр зэвсгүүдээ “булшилж, мөн тэд ямар нэгэн байдлаар нүгэл үйлдэх болуузай хэмээн тэдгээрийг авахаас та нар айдаг; тийм ээ, тэд нүгэл үлдэхээс айдгийг та нар харж чадна—учир нь болгоогтун дайснуудаараа доор дэвслэгдэхийг мөн алагдахыг тэд өөрсдөө хүлцэх бөлгөө, мөн тэдний эсрэг илднүүдээ өргөхгүй, мөн энэ нь Христэд итгэх тэдний итгэлийн учир бөлгөө.

10 Мөн эдүгээ, тэд итгэдэг тэр зүйлдээ итгэхэд үзүүлэх тэдний тууштай чанарын учир, өөрөөр хэлбэл тэд нэгэнтээ гэгээрсний дараа үзүүлэх гуйвшгүй байдлынхаа учир, болгоогтун, тэдний алдсууд байсан хэдий ч Их Эзэн тэднийг адисалж мөн тэдний өдрүүдийг уртасгах болно—

11 Тийм ээ, бүр тэд итгэлгүйдээ бууран доройтовч, бидний эцэг өвгөдөөр, мөн

түүнчлэн бошиглогч “Зиносоор, мөн бусад олон бошиглогчоор, ах дүүс леменчүүдийг маань дахин үнэний мэдлэгт хүргэх ^бсэргээлтийн талаар яригдсан цагийг ирэх хүртэл Их Эзэн тэдний өдрүүдийг “уртасгах болно.

12 Тийм ээ, би та нарт хэлнэ, Их Эзэний “амлалтууд бидний ах дүүс, леменчүүдэд хожмын үед хүргэгдэхээр болсон ажгуу; мөн тэдэнд олон зовлон байх хэдий ч, мөн тэд газрын гадаргуу дээр ^бнааш цааш туугдана, мөн мөрдөгдөж, мөн цохигдон бас хааяагүй тараагдана, мөн хоргодох газаргүй байх хэдий ч, Их Эзэн тэдэнд “нигүүлсэнгүй байх болно.

13 Мөн энэ нь Гэтэлгэгчийнх нь мөн тэдний агуу их хийгээд жинхэнэ “хоньчны талаарх мэдлэг болох тэрхүү үнэн мэдлэгт тэд дахин ^бавчрагдана, мөн түүний хонин дунд тоологдоно гэсэн бошиглолын дагуу юм.

14 Тиймийн тул би та нарт хэлнэ, та нар наманчлахгүй аваас тэдний хувьд энэ нь та нарынхаас “илүү дээр байх болно.

15 Учир нь болгоогтун, та нарт үзүүлэгдсэн “хүчирхэг ажлууд тэдэнд, тийм ээ, эцэг өвгөдийнхөө уламжлалын учир итгэлгүйдээ бууран доройтсон тэдэнд үзүүлэгдсэн

8a Алма 23:6; 27:27;
3 Ниф. 6:14.

9a Алма 24:17–19.

11a Хил. 8:19.

б 2 Ниф. 30:5–8.

в Алма 9:16.

12a Инос 1:12–13.

б Морм. 5:15.

в 1 Ниф. 13:31;

2 Ниф. 10:18–19;

Иаков 3:5–6.

13a су Сайн Хоньчин.

б 3 Ниф. 16:12.

14a Хил. 7:23.

15a Мат. 11:20–23.

бол, тэд дахин хэзээ ч итгэлгүйдээ бууран доройтохгүйг та нар өөрсдөө үзэх бөлгөө.

16 Тиймийн тул, Их Эзэн хэлдэг: Би тэднийг бүрмөсөн устгахгүй, харин би өөрийн мэргэн ухааны тэрхүү өдөр тэднийг дахин надад эргэж ирэх болгоно хэмээн Их Эзэн хэлдэг.

17 Мөн эдүгээ болгоогтун, нифайчуудын ард түмний талаар Их Эзэн хэлсэн нь: Хэрэв тэд наманчлахгүй, мөн тааллыг минь үйлдэхийг хичээхгүй аваас, тэдний дунд миний үйлдсэн олон хүчирхэг ажил байсан ч итгэлгүйнх нь учир би тэднийг бүрмөсөн “устгах болно, хэмээн Их Эзэн хэлдэг; мөн Их Эзэн амьд нь гарцаагүйн адил эдгээр зүйл байх болно хэмээн Их Эзэн хэлдэг бөлгөө.

БҮЛЭГ 16

Самуелд итгэсэн нифайчуудад Нифай баптисм хүртээв—Үл наманчлагч нифайчуудын сум болон чулуунд Самуел алагдах нь үгүй—Зарим нь зүрх сэтгэлээ хатууруулж, мөн бусад зарим нь тэнгэр элчүүдийг харав—Үл итгэгчид Христэд мөн түүний Иерусалим дахь ирэлтэнд итгэх нь ухаалаг биш хэмээн хэлэв. Ойролцоогоор мэв 6–1 он.

Мөн эдүгээ, улиран тохиох дор, хотын хэрмэн дээр ярьсан лемен үндэстэн, Самуелын үгсийг сонссон нь олон

байв. Мөн түүний үгэнд итгэсэн болгон одож мөн Нифайг эрэлхийлэв; мөн тэд ирж мөн түүнийг олоод тэд түүнд нүглүүдээ тоочиж мөн үгүйсгэсэнгүй, тэд Их Эзэний төлөө баптисм хүртэхийг хүсэв.

2 Гэвч Самуелын үгсэд итгээгүй болгон нь түүнд уурлаж байв; мөн тэд хэрмэн дээрх түүний зүг чулуу шидэж, мөн түүнчлэн олон нь түүнийг хэрмэн дээр зогсож байхад түүний зүг сум харвав; гэвч Их Эзэний Сүнс түүнтэй хамт байв, үүний хэрээр тэд түүнийг чулуунуудаараа бас сумнуудаараа ч онож чадсангүй.

3 Эдүгээ тэд түүнийг онож чадахгүйгээ үзээд, түүний үгсэд итгэсэн нь илүү олон байв, үүний хэрээр тэд баптисм хүртэхээр Нифайн зүг одов.

4 Учир нь болгоогтун, хүмүүс Христ “удахгүй ирэх ёстойг мэдэж болохын тулд Нифай баптисм хүртээж, мөн бошиглож, мөн номлож, наманчил хэмээн тэдэнд хашгирч, тэмдгүүд хийгээд гайхамшгуудыг үзүүлж, хүмүүсийн дунд “гайхамшгуудыг үйлдэж байв—

5 Тэд итгэж болно гэсэн зорилгын тулд, тэдгээрийн ирэх цагт тэдгээр нь тэдэнд урьдаас мэдүүлэгдсэнийг тэд мэдэж мөн санаж болохын тулд, удахгүй ирэх зүйлүүдийн талаар тэр тэдэнд хэлж байв; тиймийн тул Самуелын

үгсэд итгэсэн болгон нь баптисм хүртэхээр түүнд очиж байв, учир нь тэд наманчилж мөн нүглүүдээ хүлээн хүрч ирэв.

6 Гэвч тэдний ихэнх хэсэг нь Самуелын үгсэд итгэсэнгүй; тиймийн тул тэд чулуунууд болон сумнуудаараа түүнийг онож чадахгүйгээ үзээд, тэд ахлагчиддаа хашгирч, хэлсэн нь: Энэ хүнийг баривчил, мөн түүнийг хүл, учир нь болгоогтун тэр бол чөтгөр шүглэсэн нэгэн; мөн түүнд орших чөтгөрийн хүчний учир бид түүнийг чулуунууд мөн сумаараа онож чадахгүй; тиймийн тул түүнийг барьж мөн түүнийг хүлж, мөн түүнийг зайлуулагтун.

7 Мөн тэд түүнд гар хүрэхээр очиход, болгоогтун, тэрээр хэрэмнээс доош үсэрч, мөн тэдний нутгаас гарч, тийм ээ, бүр өөрийн нутагт хүртэл зугтав, мөн өөрийнхөө хүмүүсийн дунд номлож мөн бошиглож эхлэв.

8 Мөн болгоогтун, Нифайчуудын дунд тэрээр хэзээ ч дахин дуулдсангүй; мөн хүмүүсийн хэрэг явдал тийн байв.

9 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын наян зургадугаар он тийн төгсөв.

10 Мөн түүнчлэн шүүгчдийн засаглалын наян долдугаар он тийн төгсөж, уг хүмүүсийн ихэнх хэсэг нь өөрсдийн бардамнал мөн ёс бус байдалдаа

үлдэж, мөн багахан хэсэг нь Бурханы өмнө илүү хянамгай алхалж байв.

11 Мөн эдгээр нь түүнчлэн шүүгчдийн засаглалын наян наймдугаар оны нөхцөл байдал байв.

12 Мөн шүүгчдийн засаглалын наян есдүгээр онд уг хүмүүс алдастаа улам илүү хатуурч, мөн Бурханы зарлигуудын эсрэг түүнийг улам улам илүүтэй хийж эхэлснээс бусдаар бол, уг хүмүүсийн хэрэг явдалд зөвхөн ялимгүй өөрчлөлт байв.

13 Гэвч улиран тохиох дор шүүгчдийн засаглалын ердүгээр онд, хүмүүст өгөгдсөн “агуу тэмдгүүд мөн гайхамшигууд байв; мөн бошиглогчдын үгс ⁶гүйцэлдэж эхлэв.

14 Мөн “тэнгэр элчүүд хүмүүнд, мэргэн хүмүүнд үзэгдэж, мөн тэдэнд агуу их баяслын баярт мэдээг тунхаглав; энэ онд судрууд тийн гүйцэлдэж эхлэв.

15 Гэсэн хэдий ч, нифайчууд мөн түүнчлэн леменчүүдийн аль алиных нь хамгийн их итгэлтэй хэсгээс бусад нь бүгд, уг хүмүүс зүрх сэтгэлээ хатууруулж эхлэн, мөн өөрсдийнхөө чадал хийгээд “өөрсдийнхөө мэргэн ухаан дээр тулгуурлаж эхлэн, өгүүлсэн нь:

16 Ийм олны дундаас, зарим зүйлийг тэд зөв таасан байж болох юм; гэвч болгоогтун, яригдсан эдгээр агуу их хийгээд гайхамшигт ажлууд бүгд

тохион ирэх аргагүйг бид мэднэ.

17 Мөн тэд өөр хоорондоо зөрчилдөж мөн шалтаглаж эхлэв, өгүүлсэн нь:

18 Христ мэтийн тиймэрхүү хүмүүн бие ирнэ гэдэг нь “байж болмоор юм биш; хэрэв тийм аваас, мөн тэрээр яригдсанчлан Бурханы Хүү, тэнгэр болон газрын Эцэг юм бол, тэрээр Иерусалимд байх тэдэнд үзүүлснийхээ нэгэн адилаар бидэнд өөрийгөө яагаад үзүүлэхгүй байх билээ?

19 Тийм ээ, тэрээр Иерусалимын нутгийн адилаар энэ нутагт ч өөрийгөө яагаад үзүүлэхгүй байх билээ?

20 Гэвч болгоогтун, бидний дунд бус, харин алс холд байх нутагт, бидний мэдэхгүй тэр нутагт улиран тохиох ямар нэгэн агуу хийгээд гайхамшигт зүйлд биднийг итгүүлэхээр бидний эцэг өвгөдөөр доош бидэнд гардуулагдсан нь ёс бус “уламжлал гэдгийг бид мэднэ; тиймийн тул тэд биднийг харанхуй бүдүүлэг байдалд байлгаж чадна, учир нь бид өөрсдийн нүдээр тэдгээр нь үнэн гэдгийг “харах аргагүй бөлгөө.

21 Мөн уг хилэнцэт нэгний башир мөн нууц аргаар, үгсийнх нь зарц, мөн түүнчлэн өөрсдийнх нь зарц байлгах

бид ойлгох аргагүй ямар нэгэн агуу нууцыг үйлдэх болно, учир нь үгийг заалгахаар бид тэдгээрийн дээр тулгуурладаг; мөн хэрэв бид тэдэнд өөрсдийгөө мэдүүлбэл, амьдралын маань бүхий л өдрүүдэд тийн тэд биднийг харанхуй бүдүүлэг байдалд байлгах болно.

22 Мөн мунхаг болоод “хоосон, өөр олон зүйлийг хүмүүс зүрх сэтгэлдээ төсөөлсөн ажгуу; мөн тэд ихэд сандаагдсан байв, учир нь Сатан алдсыг үйлдүүлэхээр тэднийг үргэлж өдөөн хатгаж байв; тийм ээ, тэрээр уг хүмүүсийн зүрх сэтгэлийг сайны эсрэг мөн ирэх зүйлийн эсрэг хатууруулж болохын тулд, тэрээр уг нутгийн гадаргуу дээр цуурхал болоод зөрчилдөөнүүдийг тарааж явав.

23 Мөн Их Эзэний хүмүүсийн дунд хийгдсэн тэмдгүүд болон гайхамшгууд, мөн тэдний үйлдсэн олон гайхамшигт зүйл байсан хэдий ч, Сатан уг нутгийн бүх гадаргуу дээрх хүмүүсийн зүрх сэтгэлд агуу барьц олжээ.

24 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын ердүгээр он тийн төгсөв.

25 Мөн Хиламан болон түүний хөвгүүдийн цэдгийн дагуу, Хиламаны ном ийн төгсөв.

18a Алма 30:12–13.

20a су Уламжлалууд.

б Ифер 12:5–6, 19.

22a су Хоосон үг,

Хоосон үг ярих.

ГУРАВДУГААР НИФАЙ НИФАЙН НОМ

ХИЛАМАНЫ ХӨВГҮҮН АСАН ТЭР НИФАЙН ХҮҮ

Мөн Хиламан нь Иудейн хаан, Зедикаягийн хаанчлалын Мэхний жил Иерусалимаас гарч ирсэн Лихайн хүү болох Нифайн үр удам асан сайхь Алмагийн хүү асан тэрхүү Алмагийн хөвгүүн болох Хиламаны хөвгүүн билээ.

БҮЛЭГ 1

Хиламаны хүү Нифай уг нутгаас гарч одоод, мөн түүний хүү Нифай цэдгүүдийг хөтлөв— Хэдийгээр тэмдгүүд болон гайхамшигууд элбэг байвч, ёс бусыг үйлдэгчид зөв шударгыг үйлдэгчдийг хөнөөхөөр төлөвлөв— Христийн төрөлтийн шөнө тохион ирэв— Тэмдэг өгөгдөж, мөн шинэ од гарав— Худал хэлэх нь бас залилах нь нэмэгдэж, мөн Гадиантоны дээрэмчид олныг хөнөөв. Ойролцоогоор мэ 1–4 он.

ЭДҮГЭЭ улиран тохиох дор ерэн нэгдүгээр он улирч одон мөн Лихай Иерусалимыг орхисон цагаас “зургаан зуун жил боллоо; мөн энэ нь уг нутгийн дээр Лаконеус ерөнхий шүүгч бөгөөд захирагч байсан тэр жил байв.

2 Мөн Хиламаны хүү, Нифай Зарахемла нутгаас гарч явсан байв, “гуулин ялтсууд, мөн хөтлөгдсөн тэр бүх цэдгүүд, мөн Лихай Иерусалимаас гарч одсон цагаас хойш нандигнан хадгалагдсаар буй тэдгээр бүх зүйлүүдийн талаарх хариуц-

лагыг өөрийн ахмад хөвгүүн асан, хүү ⁶Нифайдаа өгөв.

3 Тэгээд тэр уг нутгаас гарч явав, мөн тэр “хааш явсныг хэн ч үл мэднэ; мөн түүний оронд хүү Нифай нь цэдгүүдийг, тийм ээ, энэ хүмүүсийн цэдгийг хөтлөв.

4 Мөнхүү улиран тохиох дор ерэн хоёрдугаар оны эхэнд, болгоогтун, бошиглогчдын бошиглолууд илүү ихээр гүйцэлдэж эхлэв; учир нь илүү агуу дохионууд мөн илүү агуу гайхамшигт зүйлүүд уг хүмүүсийн дунд хийгдэж эхлэв.

5 Гэвч лемен үндэстэн Самуелаар “яригдсан үгс гүйцэлдэх цаг нь өнгөрсөн хэмээн хэлж эхэлсэн зарим хүмүүс байв.

6 Мөн тэд ах дүүсээ хараад бах нь ханаж эхлэн, хэлсэн нь: Болгоогтун тэр цаг өнгөрсөн, мөн Самуелын үгс гүйцэлдсэнгүй; тиймийн тул, энэ зүйлийн талаарх та нарын баясал болоод та нарын итгэл хоосон байжээ.

7 Мөнхүү улиран тохиох дор тэд уг нутаг даяар агуу самуун дэгдээв; мөн итгэсэн

[3 НИФАЙ]
1 1а 2 Ниф. 25:19.
2а Алма 37:3–5.

б су Нифай, Нифайн хүү асан Хиламаны хүү.

3а 3 Ниф. 2:9.
5а Хил. 14:2–4.

хүмүүс ихэд уйтгарлан гунж эхлэв, яригдсан тэдгээр зүйлүүд ямар нэгэн байдлаар улиран тохиохгүй байхвий хэмээснээс бөлгөө.

8 Гэвч болгоогтун, тэдний итгэл хоосон бишийг тэд мэдэж болохын тулд шөнө үгүй байсан мэт нэг өдөр лугаа адил байх тэрхүү өдөр мөн тэрхүү шөнө мөн тэрхүү өдрийг тэд тууштайгаар ажиглан хүлээж байлаа.

9 Эдүгээ улиран тохиох дор, бошиглогч Самуелаар өгөгдсөн тэмдэг улиран тохиохгүй бол тэдгээр уламжлалуудад итгэсэн тэд бүгд “үхэлд хүргэгдэх өдөр үл итгэгчдээр товлогдов.

10 Эдүгээ улиран тохиох дор Нифайн хүү Нифай өөрийн хүмүүсийн энэ ёс бус байдлыг үзээд, сэтгэл зүрх нь үлэмж харамсав.

11 Мөнхүү улиран тохиох дор тэрээр гарч мөн өөрөө газарт бөхийн, мөн өөрийн хүмүүсийн, тийм ээ, эцэг өвгөдийнхөө уламжлалд итгэсний учир устгагдах гэж буй тэдний тусын тулд Бурхандаа хүчтэйгээр залбиран гуйв.

12 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр тэрхүү “өдрийн туршид Их Эзэнд хүчтэйгээр залбиран гуйв; мөн болгоогтун, Их Эзэний дуу хоолой түүнд ирж, хэлсэн нь:

13 Тэргүүнээ өргөгтүн мөн

урамтай байгтун; учрыг болгоогтун, цаг нь ойртлоо, мөн энэ шөнө тэмдэг өгөгдөх болно, мөн ариун бошиглогчдынхоо амаар өөрийн “яриулсан бүгдийг би гүйцэлдүүлэх болно гэдгийг дэлхийд үзүүлэхээр ^бмаргааш бибээр дэлхийд ирэх болно.

14 Болгоогтун, дэлхийн “үүслээс хүмүүний үрсэд миний мэдүүлсэн тэр бүх зүйлийг ^бгүйцэлдүүлэхээр, мөн Эцэгийн мөн Хүүгийн—миний учир Эцэгийн, мөн бие махбодийн минь учир Хүүгийн “аль алиных нь тааллыг үйлдэхээр би өөрийнхөндөө ‘ирнэ. Мөн болгоогтун, цаг нь ойртлоо, мөн энэ шөнө тэмдэг өгөгдөх болно.

15 Мөнхүү улиран тохиох дор Нифайд ирсэн тэр үгс нь, яригдсаныхаа дагуу гүйцэлдэв; учрыг болгоогтун, нар шингэхэд харанхуй болсонгүй; мөн шөнө болоход “харанхуй болсонгүйн учир хүмүүс гайхаш тасарч эхлэв.

16 Мөн бошиглогчдын үгсэд итгээгүй байсан нь, газарт “унаж мөн үхсэн мэт болцгоосон нь олон байв, учир нь бошиглогчдын үгсэд итгэсэн тэдэнд төлөвлөсөн устгалын агуу ^бтөлөвлөгөө бүтэлгүй болсныг тэд мэдсэн ажээ; учир нь өгөгдсөн тэрхүү тэмдэг ирчихсэн байв.

17 Мөн Бурханы Хүү удахгүй

9а су Санаатайгаар алах, Санаатай аллага.
12а Инос 1:4; Алма 5:46.
13а су Есүс Христ— Есүс Христийн төрөлт

болон нас баралтын тухай бошиглол.
б Лук 2:10–11.
14а Алма 42:26.
б Мат. 5:17–18.

в С ба Г 93:3–4.
г Иохан 1:11.
15а Хил. 14:3.
16а Хил. 14:7.
б 3 Ниф. 1:9.

үзэгдэх ёстойг тэд мэдэж эхлэв; тийм ээ, эцэст нь өрнөдөөс дорнодыг хүртэл, умард нутаг мөн өмнөд нутгийн аль алинд нь бүх газрын гадаргуу дээрх бүх хүмүүс үлэмж их дочирдон гайхсанаас тэд газарт унав.

18 Учир нь бошиглогчид эдгээр зүйлийн тухай олон жилийн турш гэрчилж байсныг, мөн өгөгдсөн тэрхүү тэмдэг ирчихсэнийг тэд мэдэв; мөн тэд өөрсдийн алдас мөн итгэлгүйнхээ учир айж эхэлсэн бөлгөө.

19 Мөнхүү улиран тохиох дор тэр шөнийн турш харанхуй байсангүй, харин энэ нь үд дунд лугаа адил гэрэлтэй байв. Мөнхүү улиран тохиох дор өглөө нь нар зохих ёсныхоо дагуу, дахин мандсан болой; мөн энэ нь Их Эзэний “төрөх өдөр байсныг өгөгдсөн тэмдгийн учир тэд мэдсэн ажгуу.

20 Мөнхүү энэ нь, тийм ээ, бүх зүйлүүд, бошиглогчдын үгсийн дагуу, нэг бүрчлэн улиран тохиожээ.

21 Мөнхүү улиран тохиох дор түүнчлэн нэгэн шинэ “од үгийн дагуу үзэгдэв.

22 Мөнхүү улиран тохиох дор энэ үеэс эхлэн, тэд үзсэн тэрхүү тэмдгүүд хийгээд гайхамшгууддаа итгэхгүй байж болно гэсэн зорилготойгоор зүрх сэтгэлийг нь хатууруулахаар худал хуурмагууд, хүмүүсийн дунд Сатанаар

илгээгдэж эхлэв; гэвч эдгээр худал хуурмагууд хийгээд заль мэх байсан хэдий ч, хүмүүсийн ихэнх хэсэг нь итгэж, мөн Их Эзэнд хөрвүүлэгдэв.

23 Мөнхүү улиран тохиох дор Нифай мөн түүнчлэн бусад олон нь хүмүүсийн дунд одож, наманчлалд хүргэн баптисм хүртгээв, үүний улмаас нүглүүдийн агуу “ангижрал байв. Мөн уг нутагт хүмүүс дахин тийн амар амгалан байх болов.

24 Мөн Мосегийн хуулийг дагах нь цаашид “зайлшгүй биш хэмээн судруудаар батлахыг оролдон, номлож эхэлсэн цөөн хэдээс бусдаар бол зөрчилдөөнүүд үгүй байв. Эдүгээ судруудыг ойлгоогүйн учир энэ зүйлийн хувьд тэд алджээ.

25 Гэвч улиран тохиох дор тэд удалгүй хөрвүүлэгдэж, мөн тэд байгаа тэр алдаандаа үнэмшүүлэгдэв, учир нь хууль хараахан “гүйцэлдээгүй байсан нь, мөн энэ нь нэг бүрчлэн гүйцэлдэх ёстой нь тэдэнд мэдүүлэгдсэн байв; тийм ээ, энэ нь гүйцэлдэх ёстой гэсэн үг тэдэнд ирэв; тийм ээ, энэ нь бүгд гүйцэлдэх хүртэл нэг зураас, эсвээс нэг үсэг ч гээгдэхгүй; тиймийн тул мөнхүү онд тэд өөрсдийнхөө алдааны мэдлэгт авчрагдаж мөн буруугаа ⁶хүлээцгээв.

26 Мөн бүх ариун бошиглогчдын бошиглолын үгсийн

19a Лук 2:1–7.
21a Мат. 2:1–2;
Хил. 14:5.

23a су Нүглүүдийн
ангижрал.
24a Алма 34:13.

25a Мат. 5:17–18.
б Мозая 26:29.

дагуу улиран тохиосон тэмдгүүдийн учир хүмүүст баярт мэдээг авчран, ерэн хоёрдугаар он тийн улиран одов.

27 Мөнхүү улиран тохиох дор уулсын дээр оршсон, уг нутагт бужигналдсан, “Гадантоны дээрэмчдээс бусдаар бол, ерэнгуравдугаар он ч түүнчлэн амар амгаланд улирч одов; учир нь тэдний бэхлэлтүүд хийгээд нууц байрууд нь хүмүүс тэднийг хүчээр дийлж чадахааргүй тийм бат бөх байв; тиймийн тул тэд олон аллага үйлдэж, мөн хүмүүсийн дунд их хядлага үйлдсэн болой.

28 Мөнхүү улиран тохиох дор нифайчуудаас тэрсэлсэн олон нь тэдэнд зугтан очсон учир ерэн дөрөвдүгээр онд тэд агуу зэрэгт өсөн нэмэгдэж эхлэв, иймээс нутагтаа үлдсэн нифайчуудад их харамсал учруулав.

29 Мөн леменчүүдийн дунд ч их харамслын шалтгаан түүнчлэн байв; учир нь болгоогтун, өсөж том болсон мөн нас бие гүйцэж эхэлсэн, тиймээс биеэ даах болсон мөн Гадантоны дээрэмчидтэй нэгдэхээр “зорамчууд болох зарим хүмүүсээр, тэдний худал хуурмагаар, мөн тэдний зусар үгсээр зайлуулан удирдагдсан олон хүүхэд тэдэнд байв.

30 Мөн ийн леменчүүд ч түүнчлэн зовж байв, мөн өсвөр үеийнхний ёс бүс

байдлын учир итгэл хийгээд зөв шударга байдлын хувьд тэд доройтож эхлэв.

БҮЛЭГ 2

Хүмүүсийн дунд ёс бус хийгээд жигшүүрт үйлүүд нэмэгдэв— Гадантоны дээрэмчдийн эсрэг нифайчууд болон леменчүүд өөрсдийгөө хамгаалахын төлөө нэгдэв— Хөрвүүлэгдсэн леменчүүд цагаан болж, нифайчууд хэмээн нэрлэгдэх болов. Ойролцоогоор мэ 5–16 он.

Мөнхүү улиран тохиох дор тийн ерэн тав дахь он түүнчлэн улирч одов, мөн хүмүүс өөрсдийн сонссон тэмдгүүд болоод гайхамшгуудыг мартаж эхлэв, мөн тэнгэрээс ирэх аливаа тэмдэг эсвээс гайхамшигт улам багаар цочирдон гайхах болж эхлэв, үүний хэрээр тэд зүрх сэтгэлдээ хатуу, мөн оюун санаандаа харалган болж эхлэв, мөн тэд сонссон мөн харсан бүхэндээ итгэхгүй болж эхлэв—

2 Хүмүүсийн зүрх сэтгэлийг “залилан мөн буруу тийш дагуулахын тулд, тэр нь хүмүүнээр мөн чөтгөрийн хүчээр үйлдэгдсэн хэмээн ямар нэгэн хоосон зүйлийг зүрх сэтгэлдээ төсөөлснөөс буюу; мөн хүмүүсийн зүрх сэтгэлийг Сатан дахин тийн эзэмшив, үүний хэрээр тэрбээр тэдний мэлмийг харалган болгож мөн Христийн сургаал бол

мунхаг мөн хоосон зүйл гэдэгт тэднийг итгүүлэхээр дагуулав.

3 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс ёс бус хийгээд жигшүүрт үйлд хүчирхэг болж эхлэв; мөн тэмдгүүд болон гайхамшгууд цаашид өгөгдөнө гэдэгт тэд итгэсэнгүй; мөн Сатан “явж, хүмүүсийн зүрх сэтгэлийг дагуулан, тэднийг уруу татан мөн тэднийг уг нутагт агуу ёс бусыг хийхэд хүргэв.

4 Мөн тийн ерэнзургаа дахь; мөн түүнчлэн ерэндолоо дахь; мөн түүнчлэн ерэннайм дахь; мөн түүнчлэн ерэн ес дэх он улирч одов;

5 Мөн түүнчлэн нифайчуудын ард түмний дээрх хаан асан “Мозаягийн өдрүүдээс хойш зуун жил улирч одсон байв.

6 Мөн Лихай Иерусалимыг орхисноос хойш зургаан зуун есөн жил улирч одсон байлаа.

7 Мөн Христ дэлхийд ирэх болно хэмээн бошиглогчдоор яригдсан тэрхүү тэмдэг өгөгдсөнөөс хойш есөн жил улирч оджээ.

8 Эдүгээ нифайчууд тэмдэг өгөгдсөн энэ үеэс, өөрөөр хэлбэл Христийн ирэлтээс цаг хугацаагаа тоолох болжээ; тиймийн тул, есөн жил улирч оджээ.

9 Мөн Нифайн эцэг асан, цэдгүүдийг хариуцаж байсан Нифай Зарахемлагийн нутагт “эргэж ирсэнгүй, мөн бүх нутагт хаана ч олдохгүй байв.

10 Мөнхүү улиран тохиох дор ихээхэн номлол мөн бошиглол тэдний дунд илгээгдсэн хэдий ч хүмүүс ёс бус байдалдаа хэвээр үлдэв; мөн тийн арав дахь он түүнчлэн улирч одов; мөн арваннэг дэх он түүнчлэн алдаст улирч одов.

11 Мөнхүү улиран тохиох дор арвангурав дахь онд бүх нутаг даяар дайнууд мөн зөрчлөдөөнүүд байж эхлэв; мөн хүмүүсээс тийм олныг нь хөнөөж, мөн тийм олон хотыг устгаж, мөн уг нутаг даяар тийм их үхэл мөн алаан хядаан тараасны учир бүх хүмүүсийг, нифайчууд мөн леменчүүдийн аль алиныг нь тэдний эсрэг зэр зэвсэг барихаас аргагүй болгосон Гадантоны дээрэмчид тийн маш олон тоотой болсон аж.

12 Тиймийн тул, Их Эзэнд хөрвүүлэгдсэн бүх леменчүүд өөрсдийн ахан дүүс болох нифайчуудтай нэгдэв, мөн өөрсдийн амь нас мөн эмэгтэйчүүд болон хүүхдүүдийнхээ аюулгүй байдлын төлөө, тийм ээ, мөн өөрсдийн эрхийг, мөн өөрсдийн сүмийн хийгээд өөрсдийн сүсэг бишрэлийн онцгой боломж, мөн өөрсдийн “эрх чөлөө хийгээд өөрсдийн “чөлөөт байдлыг хадгалан хамгаалахаар Гадантоны дээрэмчдийн эсрэг зэвсэг барихаар албадуулагджээ.

13 Мөнхүү улиран тохиох дор энэ арвангурав дахь он улирч одохын өмнө үлэмж ширүүн

болсон энэхүү дайны улмаас нифайчууд бүрэн устгалаар заналхийлэгдэв.

14 Мөнхүү улиран тохиох дор нифайчуудтай нэгдсэн леменчүүд нифайчуудын дунд тоологдов;

15 Мөн тэдний “зүхэл тэднээс авагдаж, мөн тэдний арьс нифайчуудынхтай адил цагаан болжээ;

16 Мөн тэдний залуу эрэгтэйчүүд мөн тэдний охид үлэмж царайлаг болж, мөн тэд нифайчуудын дунд тоологдож, мөн нифайчууд хэмээн нэрлэгдэв. Мөн тийн арван гуравдугаар он төгсөв.

17 Мөнхүү улиран тохиох дор арвандөрөвдүгээр оны эхэнд, дээрэмчид мөн Нифайн хүмүүсийн хооронд дайн үргэлжилж мөн үлэмж ширүүн болов; гэсэн хэдий ч, Нифайн хүмүүс дээрэмчдийн дээр зарим давуу талыг олж, үүний хэрээр тэд нутгаасаа тэднийг ухраан ууланд мөн тэдний нууц газрууд тийш хөөв.

18 Мөн ийн арван дөрөвдүгээр он төгсөв. Мөн арвантавдугаар онд тэд Нифайн хүмүүсийн эсрэг давшин ирэв; мөн Нифайн хүмүүсийн ёс бусын, мөн тэдний олон зөрчилдөөн мөн тэрслэлүүдийн улмаас, Гадиантоны дээрэмчид тэдний дээр олон давуу тал олж авсан ажээ.

19 Мөн ийн арвантав дахь он төгсөж, мөн тийн уг хүмүүс олон зовлон зүдгүүрийн байдалд байв; мөн устгалын

“илд тэдний дээр далайгдаж, үүний хэрээр тэд түүгээр цохигдох гэж байв, мөн энэ нь тэдний алдсын улмаас буюу.

БҮЛЭГ 3

Гадиантоны удирдагч, Гидианхай өөрсдийгөө болон нутгаа өгөхийг Лаконеус түүнчлэн нифайчуудаас шаардав — Лаконеус их цэргийн ерөнхий ахлагчаар Гидгиддонайг томилов — Нифайчууд өөрсдийгөө хамгаалахаар Зарахемла болон Өгөөмөрт цугларцгаав. Ойролцоогоор мэ 16–18 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Христийн ирэлтээс хойш арванзургадугаар онд, уг нутгийн захирагч, Лаконеус, дээрэмчдийн энэ бүлэглэлийн удирдагч бөгөөд захирагчаас захидал хүлээн авав; мөн бичигдсэн тэр үгс нь эдгээр байв, өгүүлсэн нь:

2 Тус нутгийн хамгийн эрхэм хүндэт мөн ерөнхий захирагч, Лаконеус, болгоогтун, би энэ захидлыг танд бичиж, мөн өөрсдийн эрх мөн чөлөөт байдал болох үүнийгээ хадгалан хамгаалахад таны гуйвшгүй чанар мөн түүнчлэн таны хүмүүсийн гуйвшгүй чанарын учир танд үлэмж агуу магтаал өргөө; тийм ээ, та нар хэн нэгэн Бурханы мутраар дэмжигдсэн мэтээр чөлөөт байдлаа, мөн хөрөнгөө, бас улс орноо, өөрөөр хэлбэл та нар өөрсдийн тийн нэрлэх тэрнийгээ батлан

хамгаалахаар та нар сайн эсэргүүцэн зогсож байна.

3 Мөн миний захиргаанд буй — нифайчуудыг дайрч мөн тэднийг устга гэсэн үгийг ихэд тэсч ядан хүлээж байгаа, энэ үед эвэсэгтэйгээ зогсож буй ийм олон зоригт эрсийг та нар сөрөн зогсож чадна хэмээн бодсоноос ийм мунхаг болоод ихэрхүү байгаа нь надад өрөвдмөөр харагдана, эрхэм хүндэт Лаконеус.

4 Мөн би, тэднийг тулалдааны талбарт сорьсон учир тэдний тогтоон барихын аргагүй зоригийг мэдэхийн учир, мөн тэдэнд хийсэн та нарын олон буруугийн улмаас та нарын зүг чиглэсэн үүрдийн үзэн ядалтыг нь мэдэхийн учир, тиймийн тул хэрэв тэд та нарын эсрэг ирэх аваас тэд та нарт бүрмөсөн устгалаар зочлох болно.

5 Тиймийн тул, та нарын зөв хэмээн итгэсэн түүндээ гуйвшгүй чанд, мөн та нарын тулалдааны талбар дахь эр зоригийн учир, та нарын сайн сайхны төлөө зовнисон учир, би энэ захидлыг бичиж, үүнийг өөрийнхөө гараар лацдав.

6 Тиймийн тул, тэд та нарт илдтэйгээр зочилж мөн устгал та нарын дээр ирэхийн оронд та нар миний энэ хүмүүст хотуудаа, нутгаа, мөн эзэмшлүүдээ өгтүгэй хэмээн хүсэмжилсний учир би танд бичлээ.

7 Эсвээс өөрөөр хэлбэл, өөрсдийгөө бидэнд өгч, мөн бидэнтэй нэгдэж мөн бидний “нууц ажлуудтай танил болцгоо, мөн та нар бидэнтэй адил байж болохын тулд — бидний боолууд бус, харин бидний ахан дүүс мөн бидний бүх хөрөнгийг хамтран эзэмшигч бидний ах дүүс болцгоо.

8 Мөн болгоогтун, би танд “тангараг тавин амлая, хэрэв та нар үүнийг хийвэл, та нар устгагдахгүй, гэвч хэрэв та нар үүнийг хийхгүй бол, би танд тангараг тавин амлая, дараагийн сард ч та нарын эсрэг очихыг Сатанаар зарлиг болгуулна, мөн тэд гараа татахгүй мөн хэлтрүүлэхгүй, харин та нарыг хөнөөх болно, мөн та нарыг бүр үгүй болох хүртэл илдээ та нар дээр буулгах болно.

9 Мөн болгоогтун, би бол Гидианхай; мөн би бол; энэхүү бүлгийг мөн түүний ажлууд “сайн болохыг нь мэддэг Гадиантоны энэхүү ^бнууц бүлэглэлийн захирагч; мөн эдгээр нь “эртний үеийнх бөгөөд эдгээр нь бидэнд доош гардуулагдсаар ирсэн бөлгөө.

10 Мөн би энэ захидлыг танд бичиж байна, Лаконеус, мөн та нар нутгаа мөн эзэмшлүүдээ цус урсгалгүйгээр өгнө гэдэгт би найдаж байна, тэдний төр барих эрхүүдийг нь хорьсон та нарын ёс бусын учир та нараас тэрсэлсэн

3 7а Хил. 6:22–26.
8а Ифер 8:13–14.
9а Алма 30:53.

б су Нууц
хуйвалдаанууд.
в Хил. 6:26–30;

Моце 5:29, 49–52.

миний энэ хүмүүс өөрсдийн эрхүүд мөн төрөө сэргээж болохын төлөө байгаа билээ, мөн та нар үүнийг хийхгүй бол, би тэдний өшөөг авах болно. Би бол Гидианхай.

11 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор Лаконеус энэ захидлыг хүлээн аваад, нифайчуудын нутгийн эзэмшлийг шаардаж, мөн түүнчлэн уг хүмүүсийг заналхийлж мөн тэдгээр ёс бус хийгээд жигшүүрт дээрэмчдэд тэрслэн очиж өөрсдийгөө “сүйтгэснээс бусдаар бол, огт сүйтгэгдээгүй тэдний сүйтгэгдсэний өшөөг авах гэсэн Гидианхайн ичгүүр сонжуургүйн учир тэр үлэмж их гайхав.

12 Эдүгээ болгоогтун, энэ Лаконеус, захирагч нь, шударга хүн байж, мөн “дээрэмчний шаардлагууд мөн заналхийллүүдээр сүрдүүлэгдсэнгүй; тиймийн тул тэрээр дээрэмчдийн захирагч Гидианхайн захидлыг анхаарсангүй, харин тэрээр өөрийн хүмүүсийг Их Эзэнд хандан, дээрэмчид тэдний эсрэг ирэх цагийн тулд хүч чадлыг гуйхаар болгов.

13 Тийм ээ, тэд өөрсдийн эмэгтэйчүүд, мөн хүүхдүүдээ, өөрсдийн бог болон бод малаа, мөн нутгаасаа бусад өөрсдийн бүх хөрөнгийг нэг газарт нэгтгэн цуглуулбал зохино хэмээн тэрээр бүх хүмүүсийн дунд тунхаг бичиг илгээв.

14 Мөн тэрээр өөрсдийн

эргэн тойронд бэхлэлтүүд бариулж, мөн тэдгээрийн бат бөх нь үлэмж агуу байхаар болгов. Мөн нифайчуудын хийгээд леменчүүдийн аль алиных нь, өөрөөр хэлбэл нифайчуудын дунд тоологдсон тэд бүгдийн их цэргийг өөрсдийг нь дээрэмчдээс өдөр болон шөнө ч харгалзуулахаар, мөн тэднийг харж хандуулахаар эргэн тойронд нь харуулууд болгон байрлуулав.

15 Тийм ээ, тэрээр тэдэнд хэлэв: Их Эзэн амьдын адил, та нар бүх алдсуудаа наманчилж, мөн Их Эзэнд хандан гуйн залбирахгүй аваас, та нар Гадиантоны дээрэмчдийн гараас яавч чөлөөлөгдөхгүй.

16 Мөн Лаконеусын үгс хийгээд бошиглолууд бүх хүмүүсийн дээр айдсыг авчрахаар тийм агуу хийгээд гайхамшигтай байв; мөн тэд Лаконеусын үгсийн дагуу үйлдэхээр бүх хүчээрээ чармайцгаав.

17 Мөнхүү улиран тохиох дор, дээрэмчид тэдний эсрэг аглаг буйдаас ирэх тэр цагт тэднийг удирдуулахаар нифайчуудын бүх их цэргийн дээрх ерөнхий ахлагчдыг Лаконеус томилгов.

18 Эдүгээ бүх ерөнхий ахлагчдын ерөнхий нь мөн нифайчуудын бүх цэргийн агуу удирдагч томилогдов, мөн түүний нэр “Гидгиддонай байв.

19 Эдүгээ илчлэлтийн мөн түүнчлэн “бошиглолын суу

билиг бүхий хэн нэгнийг ерөнхий ахлагчаараа томилох нь бүх нифайчуудын дунд заншил байв, (тэдний ёсон бусын үеэс бусад цагт) тиймийн тул, энэхүү Гидгиддонай нь түүнчлэн ерөнхий шүүгчийн адил тэдний дундах агуу бошиглогч байв.

20 Эдүгээ уг хүмүүс Гидгиддонайд хэлэв: Их Эзэнд залбир, мөн бид дээрэмчдийг дайрч мөн тэднийг өөрсдийнх нь газар нутагт устгаж болохын тулд, биднийг ууланд гарч мөн аглаг буйдад одохыг зөвшөөрөөч.

21 Гэвч Гидгиддонай тэдэнд хэлэв: Их Эзэн “хориглож байна; учир нь хэрэв бид тэдний эсрэг өгсөн очвол Их Эзэн биднийг тэдний гарт оруулах болно; тиймийн тул бид өөрсдийгөө нутгийнхаа төвд бэлтгэе, мөн бид бүх их цэргээ нэгтгэн цуглуулъя, мөн бид тэдний эсрэг очихгүй, харин бид тэднийг бидний эсрэг ирэх хүртэл хүлээх болно; тиймийн тул Их Эзэн амьдын адил, хэрэв бид үүнийг хийвэл тэрээр тэднийг бидний гарт оруулах болно.

22 Мөнхүү улиран тохиох дор арвандолдугаар онд, уг оны төгсгөлд, Лаконеусын тунхаглал уг нутгийн бүхэл гадаргуу дээр тэр даяар тархсан байв, мөн тэд морьдоо, мөн тэрэгнүүдээ, мөн үхэр малаа, мөн бог, мөн бод малаа, бас үр тариагаа, мөн бүх хөрөнгөө авцгааж, дайснуудынхаа

эсрэг өөрсдийгөө батлан хамгаалахаар нэгдэн цуглах тохиролцсон газартаа тэд бүгд очих хүртлээ мянга мянгаараа мөн хэдэн арван мянгаараа жигдрэн алхаж одов.

23 Мөн тохиролцсон тэр нутаг нь Зарахемлагийн нутаг, мөн Зарахемла нутаг мөн Өгөөмөр нутгийн хоорондох нутаг байв, тийм ээ, Өгөөмөр нутаг мөн Эзгүйрэл нутгийн хоорондох тэр хилийн шугаманд хүртэл байв.

24 Мөн энэ нутагт өөрсдөө нэгдэн цугласан, нифайчууд хэмээн нэрлэгдсэн олон мянган агуу хүмүүс байв. Эдүгээ Лаконеус тэднийг уг нутгийн өмнөд нутагт өөрсдөө нэгдэн цугларах болгов, “умард нутгийн дээрх тэр агуу зүхлийн учир бөлгөө.

25 Мөн тэд дайснуудынхаа эсрэг өөрсдийгөө бэхлэв; мөн тэд нэг нутагт, мөн нэг хэсэгт оршиж, мөн тэд Лаконеусаар яригдсан үгсийн төлөө айж, үүний хэрээр тэд бүх нүглүүдээ наманчилсан болой; мөн тэрээр тэднийг дайснууд нь тэдний эсрэг тулалдахаар уруудан ирэх үед “чөлөөлөх буйза хэмээн Их Эзэн Бурхандаа тэд залбирлуудаа хандуулж байв.

26 Мөн тэд дайснуудынхаа учир үлэмж харамсаж байв. Мөн Гидгиддонай тэднийг мөн өөрийн удирдамжийн дагуу дайны төрөл бүрийн “зэвсгүүд хийхээр, мөн хуяг дуулга, мөн халхавч, бас

бамбайтайгаар тэднийг хүчирхэг байхаар болгов.

БҮЛЭГ 4

Нифайчуудын их цэрэг Гидиантоны дээрэмчдийг ялав—Гидианхай алагдаж, мөн түүний залгамжлагч Зимнарайха дүүжлэгдэв—Ялалтуудынхаа төлөө нифайчууд Их Эзэнийг магтан дуулав. Ойролцоогоор мэ 19–22 он.

Мөнхүү улиран тохиох дор арваннаймдугаар оны төгсгөлд тэдгээр дээрэмчдийн их цэрэг тулалдаанд бэлтгэсэн байв, мөн толгодоос, мөн уулсаас, мөн аглаг буйдаас, мөн өөрсдийн бэхлэлтүүд, мөн нуувчнуудаасаа гэнэт давшин гарч мөн уруудан ирж эхлэв, мөн уг нутгуудын өмнөд нутагт мөн умард нутагт аль алиныг нь эзэмшилдээ авч эхлэв, мөн нифайчуудаар “эзгүйрсэн тэр бүх нутгуудыг, мөн эзгүйрэн орхигдсон хотуудыг эзэмшилдээ авч эхлэв.

2 Гэвч болгоогтун, нифайчуудаар эзгүйрүүлэгдсэн нутгуудад зэрлэг араатнууд ч бас ан ч огт байсангүй, аглаг буйдад бус аваас дээрэмчид агнах ан огт үгүй байв.

3 Мөн дээрэмчид аглаг буйдад биш аваас амьдарч чадсангүй, учир нь хүнс дутагдаж байв; учир нь нифайчууд нутгуудаа хоосон орхисон байв, мөн өөрсдийн бог мөн бод малаа мөн өөрсдийн

бүх хөрөнгөө цуглуулсан байлаа, мөн тэд нэгэн хэсэг байв.

4 Тиймийн тул, нифайчуудын эсрэг ил тулалдахаар ирэхгүйгээр, дээрэмчдэд тонох мөн хүнс олж авах ямар ч боломжгүй байв; мөн нифайчууд нэгэн бие байж, мөн маш агуу тоотой байсан учир, мөн өөрсөддөө нөөц хүнс, мөн морьд мөн үхэр мал, бас төрөл бүрийн малыг тэд долоон жилийн турш хүрэлцэхүйцээр хадгалсан байв, тэд дээрэмчдийг тэрхүү хугацааны дотор уг нутгийн гадаргуугаас устгахаар найдаж байв; мөн арван наймдугаар он тийн улирч одов.

5 Мөнхүү улиран тохиох дор арван есдүгээр онд Гидианхай нифайчуудын эсрэг тулалдахаар очих нь зайлшгүй байсныг тэрээр олж мэдэв, учир нь тэд тонуул мөн дээрэм мөн аллагаас өөрөөр амьдарч чадахгүй байв.

6 Мөн нифайчууд тэдний дээр ирж мөн тэднийг хөнөөх вий хэмээн айснаас тэд үр тариа ургуулахын тулд уг нутгийн гадаргуу дээр тархаж зүрхэлсэнгүй; тиймийн тул Гидианхай энэ онд тэр нифайчуудын эсрэг тулалдахаар очих болно хэмээн их цэрэгтээ зарлиг болов.

7 Мөнхүү улиран тохиох дор тэд тулалдахаар ирэв; мөн энэ нь зургадугаар сар байв; мөн болгоогтун, тэдний тулалдахаар ирсэн тэр өдөр агуу хийгээд аймшигтай байв;

мөн тэд дээрэмчдийн маягаар хувцасласан байв; мөн хэвлийн тус газраа хурганы арьс бүсэлж, мөн тэд цусанд будагдсан, мөн үсээ нь хусуулсан байж, мөн тэдэнд толгойн хаалт дээр нь байв; мөн хуяг дуулгын учир, мөн тэд цусанд будагдсан учир, Гидианхайн их цэргийн харагдах байдал айдас төрүүлэм хийгээд аймшигтай байлаа.

8 Мөнхүү улиран тохиох дор нифайчуудын их цэрэг, Гидианхайн их цэргийн харагдах байдлыг үзээд, тэд бүгд газарт унаж, мөн Их Эзэн Бурхандаа залбирлаа өргөн, тэрээр дайснуудынх нь гараас тэднийг чөлөөлж мөн тэднийг хэлтрүүлээч хэмээн гуйв.

9 Мөнхүү улиран тохиох дор Гидианхайн их цэрэг үүнийг хараад тэд баяслынхаа учир чанга дуугаар хашгирч эхлэв, учир нь тэдний өөрсдийнх нь их цэргийн аймшигтайн учир нифайчууд айснаас унасан хэмээн бодсон ажээ.

10 Гэвч энэ тухайд тэд эндүүрч гутарсан ажгуу, учир нь нифайчууд тэднээс айсан бус; харин тэд Бурханаасаа “эмээж, мөн хамгааллын тулд түүнд хандсан болой; тиймийн тул Гидианхайн их цэрэг тэдний дээр довтлон ирэх үед тэдэнтэй тулгарахад тэд бэлтгэгдсэн байв; тийм ээ, Их Эзэний хүч чадлаар тэд тэднийг хүлээн авсан бөлгөө.

11 Мөн уг тулалдаан энэ

зургадугаар сард эхлэв; мөн тулалдаан агуу хийгээд аймшигтай байв; тийм ээ, түүний хядлага агуу хийгээд аймшигтай байв; үүний хэрээр тэр Иерусалимыг орхисноос хойш Лихайн бүх хүмүүсийн дунд ийм их хядлага хэзээ ч мэдэгдэж байсангүй.

12 Мөн Гидианхайн үйлдсэн “заналхийллүүд хийгээд тангаргууд байсан хэдий ч, болгоогтун, нифайчууд тэднийг бут цохиж, үүний хэрээр тэд тэдний өмнө гэдрэг ухрав.

13 Мөнхүү улиран тохиох дор тэднийг аглаг буйдын хил хязгаарыг хүртэл мөрдөн хөөж, мөн зам зуур тэдний гарт орсон нэгийг ч тэд хэлтрүүлэхгүй байхаар “Гидгиддонай их цэрэгтээ зарлиг болгов; мөн тийн тэд аглаг буйдын хязгаар хүртэл, бүр Гидгиддонай зарлиг гүйцэлдэх хүртэл тэднийг мөрдөж мөн тэднийг хөнөөв.

14 Мөнхүү улиран тохиох дор зоригтойгоор зогсож мөн тэмцсэн Гидианхай, тэрээр зугтаж байхдаа мөрдөгдөв; мөн их тулааныхаа учир тэрээр сульдсанаас тэр гүйцэгдэж мөн алагдав. Мөн дээрэмчин Гидианхайн төгсгөл ийн байв.

15 Мөнхүү улиран тохиох дор нифайчуудын их цэрэг хамгаалалтын байрандаа дахин буцаж ирсэн болой. Мөнхүү улиран тохиох дор энэ арванесдүгээр он улирч одон, мөн дээрэмчид тулалдахаар дахин

ирсэнгүй; бас хорьдугаар онд ч тэд дахин ирсэнгүй.

16 Мөн хориннэгдүгээр онд тэд тулалдахаар ирсэнгүй, гэвч тэд Нифайн хүмүүсийн тал бүрээс нь ирж, эргэн тойронд нь бүслэн хаав; учир нь хэрэв тэд Нифайн хүмүүсийг нутгуудаас нь салгаж, мөн тэднийг тал бүрээс нь шахах аваас, мөн хэрэв тэд гаднын бүхий л боломжуудыг нь таслах аваас, тэднийг хүслийнх нь дагуу бууж өгөхөөр болгоно хэмээн тэд бодсон аж.

17 Эдүгээ тэд өөрсөддөө өөр нэг удирдагчийг, нэр нь Зимнарайха гэгч түүнийг томилсон байв; тиймийн тул энэхүү бүслэлтийг байрлуулах болгосон нь Зимнарайха байв.

18 Гэвч болгоогтун, энэ нь нифайчуудад завшаан болов; учир нь дээрэмчдийн хувьд нифайчуудын дээр ямар нэгэн үр дүн олохуйц хангалттай удаан бүслэн хаах нь, тэдний агуулахад хураасан их хангамжийн учир боломжгүй байв,

19 Мөн дээрэмчдийн дундах хангамжуудын ховор хомсын учир; учрыг болгоогтун, тэдний аглаг буйдад олж авсан тэр мах болох, махнаас өөр тэдэнд амь зогоох юу ч байсангүй;

20 Мөнхүү улиран тохиох дор уг аглаг буйдад “зэрлэг ан нүдний гэм болж, үүний хэрээр дээрэмчид өлсгөлөнгөөр мөхөх нь холгүй байв.

21 Мөн нифайчууд өдрөөр

ч шөнөөр ч үргэлж гадагш жагсаж, мөн тэдний их цэргийг довтолж, тэднээс мянга мянгаар нь мөн хэдэн арван мянгаар нь хөнөөж байв.

22 Мөн, өдрөөр мөн шөнөөр тэдний дээр ирсэн тэр агуу устгалын учир ийн Зимнарайхагийн хүмүүс төлөвлөснөөсөө ухрах хүсэлтэй болов.

23 Мөнхүү улиран тохиох дор тэд бүслэлтээс өөрсдөө ухарч, мөн умард нутгийн хамгийн алсын хэсгүүд тийш жагсан одох зарлигийг Зимнарайха өөрийн хүмүүст өгөв.

24 Мөн эдүгээ, Гидгиддонай тэдний төлөвлөснийг мэдэж, мөн хүнс дутагдсаны учир тэдний сульдсаныг, мөн тэдний дунд хийгдсэн агуу хядлагыг мэдэж байснаас, тиймийн тул тэрээр шөнийн цагт их цэргээ илгээж мөн тэдний ухрах замыг хааж, тэдний ухрах зам дээр их цэргээ байрлуулав.

25 Мөн үүнийг тэд шөнө хийсэн аж, мөн дээрэмчдийн цаад талд нь жагсаж хүрэв, иймээс маргааш нь, дээрэмчид жагсан алхаж эхлэхдээ, тэд нифайчуудын их цэргээр урд талаасаа мөн араасаа аль алианаас нь тулгагдсан аж.

26 Мөн өмнөдөд байсан дээрэмчид түүнчлэн ухрах байруудаасаа тусгаарлагдав. Мөн эдгээр бүх зүйл Гидгиддонайн зарлигаар хийгдсэн ажээ.

27 Мөн нифайчуудад өөрсдийгөө хоригдлууд болгон бууж өгсөн олон мянга нь

байв, мөн тэдний үлдсэн нь алагдсан бөлгөө.

28 Мөн тэдний удирдагч, Зимнарайха баривчлагдаж тийм ээ, бүр түүний орой дээр үхэх хүртлээ модон дээр дүүжлэгдэв. Мөн тэд түүнийг үхэх хүртэл нь дүүжлээд, тэд уг модыг газарт унагаж, мөн чанга дуугаар хашгирч хэлсэн нь:

29 Их Эзэн өөрийн хүмүүсийг зөв шударга байдалд мөн зүрх сэтгэлийн ариунд байхад нь, тиймээс хүч чадал мөн нууц бүлэглэлүүдийн учир өөрсдийг нь алахыг эрэлхийлэх тэр бүгдийг, тэд газарт унагаагдах болгож болохын тулд, бүр энэ хүн газарт унагаагдсаны адилаар хадгалан хамгаалах болтугай.

30 Мөн тэд баясаж мөн нэгэн дуугаар дахин хашгирч хэлсэн нь: Тэд хамгааллын төлөө Бурханыхаа нэрийг “дуудаж байгаа цагт” Абрахамын Бурхан, мөн Исаакийн Бурхан, мөн Иаковын Бурхан, энэ хүмүүсийг зөв шударга байдалд нь хамгаалах болтугай.

31 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгд нэгэн зэрэг дуулж эхлэв; мөн дайснуудынхаа гарт орохоос нь тэднийг хамгаалахад, тэдний төлөө түүний хийсэн тэр агуу их зүйлийн төлөө Бурханаа “магтан дуулав.

32 Тийм ээ, тэд хашгирч: Бүхний Дээд Бурханд “Хосанна.

Мөн тэд хашгирч: “Бүхнийг Чадагч Их Эзэн Бурхан, Бүхний Дээд Бурханы нэр алдаршиг хэмээв.

33 Мөн тэднийг дайснуудынх нь гараас чөлөөлж буй Бурханы агуу сайн сайхны учир их нулимс асгаруулах хүртлээ, тэдний сэтгэл зүрх баяслаар бялхав; мөн тэд үүрдийн устгалаас чөлөөлөгдсөний учир нь тэдний наманчлал хийгээд тэдний даруу байдал гэдгийг тэд мэдсэн бөлгөө.

БҮЛЭГ 5

Нифайчууд наманчилж мөн нүглүүдээ орхив—Мормон өөрийн хүмүүсийн түүхийг бичиглэж мөн тэдэнд үүрдийн үгийг тунхаглав—Израил урт удаан тараагдалтаасаа цуглуулагдах болно. Ойролцоогоор мэ 22–26 он.

Мөн эдүгээ болгоогтун, бүх ариун бошиглогчдын ярьсан үгсэд өчүүхэн ч гэсэн эргэлзсэн нэгээхэн ч амьд бодгаль нифайчуудын бүх ард түмний дунд байсангүй; учир нь тэдгээр нь зайлшгүй гүйцэлдэх ёстойг тэд мэдсэн байлаа.

2 Мөн бошиглогчдын үгсийн дагуу өгөгдсөн олон тэмдгүүдийн учир, Христ ирсэн нь зайлшгүй байх ёстойг тэд мэдсэн бөлгөө; мөн аль хэдийн улиран тохиосон зүйлүүдийн учир, яригдсан

30a Ифер 4:15.
б Алма 29:11.

31a Алма 26:8.
су Талархалтай,

Талархах, Талархал
өргөх.

32a су Хосанна.
б 1 Ниф. 1:14.

су Бурхан, Бурхан
тэргүүтэн.

тэрний дагуу бүх зүйл улиран тохиох нь зайлшгүйг тэд мэдэж байв.

3 Тиймийн тул тэд бүх нүглүүдээ мөн жигшүүрт хэргүүдээ, мөн садар самуун явдлуудаа орхиж, мөн өдөр болоод шөнө Бурханд байдгаараа хичээнгүйлэн үйлчилж байлаа.

4 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор тэд бүх дээрэмчдийг хоригдлууд болгон баривчилж, үүний хэрээр тэднээс алагдаагүй хэн нь ч зугтаж чадсангүй, тэд хоригдлуудаа шоронд хаяж, мөн Бурханы үгийг тэдэнд номлогдохоор болгов; мөн нүглүүдээ наманчилж мөн тэд цаашид аллага үйлдэхгүй гэсэн гэрээнд орсон болгон “чөлөөт байдалд суллагдав.

5 Харин гэрээнд ороогүй тэр, мөн зүрх сэтгэлдээ тэдгээр нууц аллагуудаа үргэлжлүүлэн агуулсаар л байсан тэр болгон нь, тийм ээ, ах дүүсийнхээ эсрэг заналхийлэл үүсгэж байгаа нь мэдэгдсэн болгон нь хуулийн дагуу яллагдаж мөн шийтгэгдэв.

6 Мөн тийм их ёс бус мөн тийм их аллагууд үйлдэгдсэн тэдгээр бүх ёс бус, мөн нууц, мөн жигшүүрт бүлэглэлүүдэд тэд тийн төгсгөлийн цэг тавьсан билээ.

7 Мөн “хоринхоёр дахь он, мөн түүнчлэн хорин гурав дахь ч, мөн хорин дөрөв, мөн хорин тав дахь ч тийн улирч

одов; мөн хорин таван жил тийн улирч одсон байв.

8 Мөн зарим хүмүүсийн нүдэнд агуу хийгээд гайхамшигт болох олон зүйл тохиосон байв; гэсэн хэдий ч, тэд бүгд энэ номонд бичигдэх аргагүй; тийм ээ, энэ ном нь уг хорин таван жилийн хугацаанд тийм олон хүмүүсийн дунд хийгдсэний “зууны нэгийг нь ч агуулж чадахгүй;

9 Гэвч болгоогтун энэ хүмүүсийн бүхий л үйлүүдийг агуулдаг “цэдгүүд байдаг; мөн илүү богинохон хэдий ч үнэн шастир Нифайгаар өгөгдсөн билээ.

10 Тиймийн тул би эдгээр зүйлийн талаарх өөрийн цэдгийг Нифайн ялтсууд гэж нэрлэгдсэн ялтсууд дээр сийлбэрлэгдсэн Нифайн цэдгийн дагуу хийв.

11 Мөн болгоогтун, өөрийнхөө гараар хийсэн ялтсууд дээр би энэхүү цэдгийг хөтөлж байна.

12 Мөн болгоогтун, би “Мормон гэж нэрлэгдсэн нь, уг хүмүүсийн дунд Алма сүмийг, тийм ээ, тэдний зөрчлийн дараа тэдний дунд байгуулагдсан анхны сүмийг байгуулсан нутаг болох “Мормоны нутгийн нэрээр нэрлэгдсэнээс ажээ.

13 Болгоогтун, Бурханы Хүү, Есүс Христийн шавь билээ би. Тэд үүрдийн амьдралтай байж болохын тулд түүний үгийг түүний хүмүүсийн дунд

5 4a су Эрх чөлөө.
7a 3 Ниф. 2:8.
8a 3 Ниф. 26:6–12.

9a Хил. 3:13–15.
12a Морм. 1:1–5.
б Мозая 18:4;

Алма 5:3.

тунхаглахаар түүгээр дуудагдсан бөлгөө би.

14 Мөн ариун нэгэн асан халин одогсдын залбирлууд итгэлийнх нь дагуу хэрэгжихийн учир, биеллээ олсон эдгээр зүйлийн “цэдгийг бичиглэн үлдээх нь Бурханы тааллын дагуу надад зохих зүйл болсон билээ —

15 Тийм ээ, Лихай Иерусалимыг орхисон тэр цагаас бүр эдүгээ үеийг хүртэлх цагийг эзэлсэн тэрхүү зүйлүүдийн тухай нэгэн бага цэдэг оршвой.

16 Тиймийн тул миний өдрийн эхнийг хүртэл, миний өмнө байсан тэднээр өгөгдсөн шастируудаас би өөрийн цэдгийг үйлддэг билээ;

17 Мөн тэгээд би өөрийнхөө нүдээр харсан тэр зүйлүүдийн “цэдгийг хийдэг.

18 Мөн миний хийдэг цэдэг шударга бөгөөд үнэн цэдэг гэдгийг би мэднэ; гэсэн хэдий ч бидний хэлний дагуу, бид “бичих аргагүй олон зүйл буй.

19 Мөн эдүгээ би өөрийн тухай үгсээ төгсгөл болгож, мөн надаас өмнө байсан тэр зүйлүүдийн талаарх өөрийн шастирыг бичихээ үргэлжлүүлэе.

20 Би бол Мормон, мөн Лихайн шууд удам билээ. Тэрбээр эцэг өвгөдийг маань Иерусалимын нутгаас гарган авчирч, (мөн тэр өөрөө болон

уг нутгаас түүний авчирсан тэднээс бусад “хэн ч үл мэдсэн) мөн тэрбээр надад болон миний хүмүүст бодгалиудын маань авралд хүргэх тийм их мэдлэг өгсөн учир, Бурханаа мөн өөрийн Аврагч Есүс Христийг алдаршуулах шалтгаан надад буй.

21 Тэрбээр “Иаковын “угсааг адисалсан, мөн Иосефын үр удамд “нигүүлсэнгүй байсан нь гарцаагүй билээ.

22 Мөн Лихайн хүүхдүүд түүний зарлигуудыг дагасны “хэрээр тэрээр тэднийг адисалж мөн үгийнхээ дагуу тэднийг дэгжүүлсэн билээ.

23 Тийм ээ, тэрбээр Иосефын үр удмын “үлдэгдлийг Их Эзэн Бурханых нь “мэдлэгт дахин авчрах нь гарцаагүй.

24 Мөн Их Эзэн амьд нь гарцаагүйн адил, тэрээр дэлхийн бүх гадаргуу дээгүүр тархан тараагдсан, Иаковын үр удмын бүх үлдэгдлийг дэлхийн дөрвөн зүгээс “цуглуулах болно.

25 Мөн тэрбээр Иаковын бүх угсаатай гэрээ байгуулсны учир, тиймийн тул Иаковын угсаатай байгуулсан уг гэрээ нь түүний тогтоосон цагт биелэгдэх болно, тиймээс тэдэнтэй байгуулсан түүний тэрхүү гэрээний мэдлэгт Иаковын бүх угсаа “сэргээгдэх болно.

26 Мөн тэгээд, тэд Есүс Христ,

14a Инос 1:13–18;
С ба Г 3:19–20.

17a Морм. 1:1.

18a Ифер 12:25.

20a 1 Ниф. 4:36.

21a Эхл. 32:28.

б су Израил.

в Дэд хууль 33:13–17.

22a 2 Ниф. 1:20.

23a Алма 46:24.

б 2 Ниф. 3:12.

24a су Израил—

Израилын
цугларалт.

25a 3 Ниф. 16:5.

Бурханы Хүү болох Гэтэлгэгчээ “мэдэх болно; мөн тэгээд дэлхийн дөрвөн зүгээс өөрсдийн газар нутагт, тэд тараагдсан зүгээсээ цуглуулагдах болно; тийм ээ, Их Эзэн амьдын адилаар энэ нь тэрчлэн байх болно. Амен.

БҮЛЭГ 6

Нифайчууд дэгжив—Бардамнал, хөрөнгөжилт, мөн анги давхарга ялгаран гарав—Сүм тэрслэлүүдэд хагарав—Сатан хүмүүсийг илэрхий эсэргүүцэлд удирдав—Олон бошиглогч наманчлалыг зарлаж мөн алагдав—Тэдний алуурчид засгийн газрыг эзэлж авахаар хуйвалдав. Ойролцоогоор мэ 26–30 он.

Мөнхүү эдүгээ улиран тохиох дор нифайчуудын ард түмэн хорин зургадугаар онд, хүн бүр, гэр бүлтэйгээ, бог болон бод малтайгаа, морьдтойгоо мөн үхэр малтайгаа, тэдэнд харьяалагдах юу боловч тэр бүх зүйлтэйгээ бүгд өөрсдийн газар нутагт буцаж очив.

2 Мөнхүү улиран тохиох дор бүх нөөц хүнсээ тэд идэж дуусгаагүй байв; тиймийн тул тэд өөрсдийн хэрэглээгүй тэр бүгдээ, төрөл бүрийн бүх үр тариагаа, мөн алтаа, мөн мөнгөө, мөн бүх үнэт зүйлүүдээ авч, мөн тэд умард мөн өмнөд аль алин дахь өөрсдийн газар нутагт, умард зүгийн нутагт мөн өмнө зүгийн

нутагт аль алинд нь мөн эзэмшлүүддээ буцав.

3 Мөн уг нутгийн энх амгаланг сахих гэрээнд орсон леменчүүд хэвээр үлдэх хүсэлтэй дээрэмчдэд, тэд өөрсдийн хөдөлмөрөөр амь зуух боломжтой байхын тулд, тэдний тооных нь дагуу газар өгөв; мөн тийн тэд бүх нутагт энх амгаланг тогтоосон ажгуу.

4 Мөн тэд дахин дэгжиж мөн агуу болж эхлэв; мөн хорин зургаа болон долдугаар онууд улирч одов, мөн уг нутагт агуу дэг журам байв; мөн тэд тэгш эрх мөн шударга ёсны дагуу хуулиудаа тогтоосон байв.

5 Мөн эдүгээ бүх нутагт тэд зөрчилд унахаас бусдаар бол уг хүмүүс үргэлж дэгжихэд нь хориг болох юм юу ч үгүй байв.

6 Мөн эдүгээ уг нутагт энэхүү агуу амар амгаланг тогтоосон нь Гидгиддонай, мөн шүүгч Лаконеус болон удирдагчдаар тохоогдсон тэд байв.

7 Мөнхүү улиран тохиох дор олон хот шинээр баригдав, мөн олон хуучин хот засварлагдав.

8 Мөн хотоос хотод, мөн нутгаас нутагт, мөн газраас газарт хүргэх их хөлийн олон замууд тавигдаж, мөн олон зам баригдав.

9 Мөн хорин наймдугаар он тийн улиран одож, мөн уг хүмүүс үргэлжийн энх амгалан байв.

10 Гэвч улиран тохиох дор

хорин есдүгээр онд уг хүмүүсийн дунд зарим маргаанууд байж эхлэв; мөн зарим нь үлэмж агуу баялгуудынхаа учир “бардамнал хийгээд сагсууралдаа хүртэл хөөрч, тийм ээ, бүр агуу хавчлаганд хүрэв; 11 Учир нь уг нутагт олон наймаачин, мөн түүнчлэн олон хуульч, мөн олон албан хаагч байв.

12 Мөн хүмүүс “баялгуудынхаа мөн суралцах боломжуудынхаа дагуу давхаргаараа ялгарч эхлэв; тийм ээ, ядуугийнхаа учир зарим нь харанхуй бүдүүлэг байж, мөн бусад зарим нь баялгуудынхаа учир агуу эрдэм мэдлэг хүлээн авсан ажгуу.

13 Зарим нь бардамналдаа хөөрч, мөн бусад зарим нь үлэмж даруу байжээ; бусад зарим нь уцаар мөн “хавчлага гадуурхал бас бүх төрлийн зүдгүүрүүдийг хүлээж, мөн хараал зүхлээр буцааж “хариулалгүй, харин Бурханы өмнө даруу хийгээд гэмшсэн байхад зарим нь уцаарыг уцаараар хариулж байв.

14 Мөн ийн бүх нутагт агуу тэгш бус байдал бий болж, үүний хэрээр сүм хагарч, үнэн сүсэг бишрэлд хөрвүүлэгдсэн леменчүүдийн дундах цөөн хэдээс бусад нь эхлэв; тийм ээ, үүний хэрээр гучдугаар онд бүх нутагт сүм хагарч эхлэв; мөн тэд үүнээс

салж явахгүй байв, учир нь тэд бат мөн шаргуу, мөн гуйвшгүй, бүхий л “хичээнгүй байдлаараа Их Эзэний зарлигуудыг дагахад бэлэн байв.

15 Эдүгээ хүмүүсийн энэхүү алдсын шалтгаан ийм байв—хүмүүсийг бүх төрлийн алдсыг үйлдэхэд өдөөн хатгах, мөн тэднийг бардамналд хөөргөх, хүч чадал, мөн эрх мэдэл, мөн баялгууд, мөн дэлхийн хоосон зүйлийг эрэлхийлэхэд уруу татах агуу хүчийг Сатан эзэмджээ.

16 Мөн тийн уг хүмүүсийн зүрх сэтгэлийг төрөл бүрийн алдсыг үйлдэхэд Сатан зайцуулан удирдаж байв; тиймийн тул тэд зөвхөн цөөн хэдэн жил амар амгалан байв.

17 Мөн тийн, гучдугаар оны эхэнд—чөтгөрийн “уруу талтуудаар тэднийг хааш чиглүүлэхийг хүссэн тэр зүгт чиглүүлэх, мөн тэднээс түүний хүссэн юуг боловч алдсыг үйлдэх байдалд хүмүүс удаан хугацааны турш орхигдсон байв—мөн тийн энэхүү гучдугаар оны эхэнд, тэд аймшигт ёс бус байдалд байв.

18 Эдүгээ тэд “харанхуй бүдүүлгээр нүгэл үйлдсэнгүй, учир нь өөрсдийн талаарх Бурханы тааллыг тэд мэдсэн байв, учир нь энэ нь тэдэнд заагдсан байлаа; тиймийн тул тэд Бурханы эсрэг санаатайгаар “эсэргүүцсэн ажээ.

6 10а су Бардамнал.

12а 1 Тим. 6:17–19;

Хил. 4:12.

13а су Хавчих,
Хавчлага.

б Мат. 5:39;

4 Ниф. 1:34;

С ба Г 98:23–25.

14а су Хичээл зүтгэл.

17а су Уруу татах, Уруу

таталт.

18а Мозая 3:11.

б су Эсэргүүцэл.

19 Мөн эдүгээ энэ нь Лаконеусын хүү Лаконеусын өдрүүд байв, учир нь Лаконеус эцгийнхээ суудлыг эзэлж мөн хүмүүсийг тэр онд захирсан болой.

20 Мөн тэнгэрээс “бурханлигаар нөлөөлөгдсөн мөн илгээгдсэн хүмүүс байж эхлэв, бүх нутагт хүмүүсийн дунд зогсоод, номлон мөн хүмүүсийн нүглүүд хийгээд алдсуудын тухай зоригтойгоор гэрчилж, мөн Их Эзэн өөрийн хүмүүсийн төлөө хийх гэтэлгэлийн, эсвээс өөрөөр хэлбэл, Христийн амилалтын талаар тэдэнд гэрчилж байв; мөн тэд түүний ^бүхэл хийгээд зовлонгийн тухай зоримгоор гэрчилсэн бөлгөө.

21 Эдүгээ эдгээр зүйлийн тухай гэрчилсэн тэдний учир үлэмж ууртай байсан олон хүмүүс байв; мөн ууртай байсан тэд гол төлөв ерөнхий шүүгчид, мөн ^дээд санваартан, мөн хуульчид асан байв, тийм ээ, хуульчид болох тэд бүгд эдгээр зүйлийг гэрчилсэн тэдэнд уурлаж байв.

22 Эдүгээ ямар ч хуульч бас шүүгч бас дээд санваартан уг нутгийн захирагчаар тэдний ял мутарлагдаагүй аваас хэн нэгнийг үхэлд хүргэн яллах хүчтэй байж чадахгүй байв.

23 Эдүгээ Христэд хамаарагдах зүйлүүдийн тухай гэрчилсэн тэднийг олон нь

зоригтойгоор гэрчилсэн аж, шүүгчдээр нууцаар баривчлагдаж мөн үхэлд хүргэгдсэн учир үхлийнх нь дараа болтол тэдний үхлийн тухай мэдэгдэл уг нутгийн захирагчид очоогүй байв.

24 Эдүгээ болгоогтун, уг нутгийн захирагчаас тэд эрх авснаас бусдаар бол хэн нэгнийг үхэлд хүргэх нь уг нутгийн хуулиудын эсрэг байв—

25 Тиймийн тул Зарахемлагийн нутагт, уг нутгийн захирагчид, Их Эзэний бошиглогчдыг, хуулийн дагуу бус үхэлд хүргэн ялласан эдгээр шүүгчдийн эсрэг гомдол ирэв.

26 Эдүгээ улиран тохиох дор тэд баривчлагдаж мөн уг шүүгчийн өмнө, тэд үйлдсэн гэмт хэрэгтээ, уг хүмүүсээр тогтоогдсон тэрхүү ^ахуулийн дагуу шүүгдэхээр авчрагдав.

27 Эдүгээ улиран тохиох дор тэдгээр шүүгчдэд олон найз мөн садан төрөл байв; мөн үлдсэн нь, тийм ээ, бүр бараг бүх хуульчид мөн дээд санваартнууд, өөрсдөө нэгдэн цугларч, мөн хуулийн дагуу шалгагдах болсон тэдгээр шүүгчдийн садан төрлийнхөнтэй нэгдэв.

28 Мөн тэд нэг нэгэнтэйгээ ^агэрээнд оров, тийм ээ, бүр хуучны тэднээр өгөгдсөн гэрээнд, бүх зөв шударгын эсрэг нэгтгэхээр ^бчөтгөрөөр

20а су Сүнсний удирдамж, Сүнслэгээр нөлөөлөгдөх; Бошиглогч.

б су Цагаатгах, Цагаатгал; Цовдлуулалт.
21а С ба Г 121:36–37.
су Урвалт.

26а Мозая 29:25; Алма 1:14.
28а су Нууц хуйвалдаанууд.
б Хил. 6:26–30.

өгөгдсөн мөн удирдагдсан тэрхүү гэрээнд болой.

29 Тиймийн тул Их Эзэний хүмүүсийн эсрэг тэд нэгдэж, мөн тэднийг устгахаар, мөн хуулийн дагуу хэрэгжүүлэгдэх гэж байсан тэр, шударга ёсны атгалтаас аллагын гэмтэй тэднийг чөлөөлөхөөр гэрээнд оров.

30 Мөн тэд улс орныхоо хуулийг мөн эрхийг үл ойшоов; мөн уг нутаг цаашид эрх чөлөөт бус, харин “хааны харьяат байхын тулд захирагчийг устгахаар, мөн уг нутгийн дээр хааныг тогтоохоор тэд нэг нэгэнтэйгээ гэрээ хийв.

БҮЛЭГ 7

Ерөнхий шүүгч алагдаж, засгийн газар устгагдаж, мөн хүмүүс нь овгуудад хуваагдав—Христийг эсэргүүцэгч Иаков нууц бүлэглэлийн хаан болов—Нифай наманчлалыг мөн Христэд итгэх итгэлийг номлов—Тэнгэр элчүүд түүнд өдөр тутам тохинуулж, мөн тэрбээр дүүгээ үхэгсдээс босгов—Олон нь наманчилж мөн баптисм хүртэв. Ойролцоогоор мэ 30–33 он.

Эдүгээ болгоогтун, тэд уг нутгийн дээр хааныг тогтоогоогүйг би та нарт үзүүлье; харин мөнхүү энэ онд, тийм ээ, гучдугаар он, тэд шүүлтийн суудал дээр нь устгасан, тийм ээ, уг нутгийн ерөнхий шүүгчийг хөнөөн болой.

2 Мөн хүмүүс нэг нь нөгөөгийнхөө эсрэг хуваагдав, хүн бүр өөрийн гэр бүл мөн өөрийн садан төрөл хийгээд найз нөхдйнхөө дагуу тэд нэг нь нөгөөгөөсөө овгуудад тусгаарлагдав; мөн тийн тэд уг нутгийн засгийн газрыг устгасан билээ.

3 Мөн овог болгон толгойлогч буюу удирдагчаа өөрсдийн дээр тохоосон болой; мөн тийн тэд овгууд мөн овгуудын удирдагчид болцгоов.

4 Эдүгээ болгоогтун, тэдний дунд том гэр бүл мөн олон садан төрөл мөн найз нөхөдгүй нэг ч хүн байсангүй; тиймийн тул тэдний овгууд үлэмж агуу болов.

5 Эдүгээ энэ бүгд нь хийгдэж, мөн тэдний дунд дайнууд хараахан байсангүй; мөн тэд өөрсдийгөө Сатаны хүчинд “өгсөн учир энэ бүх алдас уг хүмүүсийн дээр ирсэн байв.

6 Мөн бошиглогчдыг алсан тэдний найзууд мөн төрөл садных нь “нууц бүлэглэлийн учир засгийн газрын журам зохицуулалт устгагджээ.

7 Мөн тэд уг нутагт агуу зөрчилдөөн үүсгэж, үүний хэрээр хүмүүсийн илүү зөв шударга хэсэг нь бараг бүгд ёс бус болсон байв; тийм ээ, тэдний дунд зөвхөн цөөн хэдэн зөв шударга хүмүүс л байв.

8 Мөн “бөөлжсөө долоох нохой мэт эсвээс намагт

хөлбөрөх гахай мэт, хүмүүсийн ихэнх хэсэг нь зөв шударга байдлаасаа буцсанаас хойш тийн зургаан жил улиран одоогүй байлаа.

9 Эдүгээ уг хүмүүсийн дээр ийм агуу алдсыг авчирсан энэ нууц бүлэглэл, өөрсдөө нэгдэн цугларч, мөн тэд Иаков гэж нэрлэсэн тэр хүнийг өөрсдийн тэргүүн болгон байрлуулав;

10 Мөн тэд түүнийг хаанаа хэмээн нэрлэв; тиймийн тул тэрээр энэхүү ёс бус холбооны дээр хаан болжээ; мөн Есүсийн тухай гэрчилсэн бошиглогчдын эсрэг ярьсан сайхь голлох хэдийн нэг нь тэр байв.

11 Мөнхүү улиран тохиох дор, хүн бүр өөрийн овгийн дагуу тэдний удирдагчид өөрсдийн хуулиудаа тогтоосноос бусдаар бол тооныхоо хувьд нэгдмэл байсан хүмүүсийн овгууд шиг тийм хүчирхэг байсангүй; гэсэн хэдий ч тэд дайснууд байв; тэд зөв шударга хүмүүс байгаагүй хэдий ч, засгийн газрыг устгахаар гэрээнд орсон тэдэнд хонзогносондоо өөр хоорондоо нэгдсэн байв.

12 Тиймийн тул, Иаков дайснууд нь тэднээс илүү олон тоотойг хараад, тэрээр уг холбооны хаан байсан учир, тиймийн тул тэрслэгчдээр өргөжих хүртлээ, (учир нь тэрбээр олон тэрслэгчид байх болно хэмээн тэднийг зусардав) мөн тэд уг хүмүүсийн

овгуудтай тэмцэх хангалттай хүчтэй болтлоо, тэд нутгийн алс умардын хэсэгт зугтан очиж, мөн тэнд өөрсдөдөө “хаант улс босгохыг тэрбээр өөрийн хүмүүст зарлиг болгов; мөн тэд ийн үйлдэв.

13 Мөн тэдний жагсаал хүмүүс хүрэх зайнаас холдох хүртлээ саатуулагдахааргүй тийм хурдан байв. Мөн гучдугаар он ийн төгсөв; мөн Нифайн хүмүүсийн хэрэг явдлууд ийн байв.

14 Мөнхүү улиран тохиох дор гучин нэг дэх онд, хүн бүр өөрийн гэр бүл, төрөл садан хийгээд найз нөхдийнхөө дагуу тэд овгуудад хуваагдсан байв; гэсэн хэдий ч тэд нэг нэгэнтэйгээ дайтахаар явахгүй гэсэн тохиролцоонд хүрчээ; гэвч тэд хуулиудаараа, мөн засгийн газрын байдлаараа нэгдмэл бус байв, учир нь тэд толгойлогчид бөгөөд удирдагчид нь асан тэдний бодлын дагуу тогтоогдов. Харин тэд нэг овог нөгөөгийнхөө эсрэг халдахгүй гэсэн маш чанд хуулиудыг тогтоож, үүний хэрээр уг нутагт ямар нэгэн хэмжээгээр тэд амар амгалан байв; гэсэн хэдий ч, тэдний зүрх сэтгэл Их Эзэн Бурханаасаа эргэсэн байв, мөн тэд бошиглогчдыг чулуугаар шидэж мөн тэднийг өөрсдийн дундаас зайлуулан гаргажээ.

15 Мөнхүү улиран тохиох дор “Нифай — тэнгэр элчүүдээр мөн түүнчлэн Их Эзэний дуу

хоолойгоор зочлогдсон учир, тиймийн тул тэнгэр элчүүдийг харж, мөн нүдээр үзэн гэрч болж, мөн тэрбээр Христийн тохинууллын талаар мэдэж болохын тулд түүнд хүч өгөгдсөн байв, мөн түүнчлэн тэд зөв шударгаас ёс бусад мөн жигшүүрт хэргүүдэд хурдан эргэхийг нүдээр үзсэн гэрч байсан учир;

16 Тиймийн тул, тэдний зүрх сэтгэлийнх нь хатуу мөн оюуных нь харалганы улмаас гашуудсан учир — мөнхүү онд тэдний дунд очиж, мөн Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр ирэх наманчлал хийгээд нүглүүдийн ангижралыг зоригтойгоор гэрчилж эхлэв.

17 Мөн тэрбээр тэдэнд олон зүйлийг тохинуулсан болой; мөн тэдгээр нь бүгд бичигдсэн байх аргагүй, мөн тэдгээрийн нэг хэсэг нь хангалттай бус болой, тиймийн тул тэдгээр нь энэ номонд бичигдсэнгүй. Мөн Нифай “хүчтэйгээр мөн агуу эрх мэдэлтэйгээр тохинуулсан болой.

18 Мөнхүү улиран тохиох дор бүр тэрбээр тэднээс илүү агуу хүчтэй байснаас тэд түүнд уурлаж байв, учир нь тэд түүний үгсэд үл итгэх нь “боломжгүй байлаа, учир нь Их Эзэн Есүс Христэд итгэх түүний итгэл агуу байснаас тэнгэр элчүүд түүнд өдөр бүр тохинуулж байв.

19 Мөн Есүсийн нэрээр тэр чөтгөрүүдийг мөн “цэвэр бус

сүнснүүдийг зайлуулав; мөн дүү нь хүмүүсээр чулуугаар шидүүлж үхлийг амссаны дараа тэрбээр түүнийг бүр нас барагсдаас босгосон болой.

20 Мөн хүмүүс үүнийг харж, мөн үүнийг үзэж, мөн түүний хүчний учир түүнд уурлаж байв; мөн түүнчлэн тэрбээр хүмүүсийн нүдэн дээр, Есүсийн нэрээр өөр “олон гайхамшиг үйлджээ.

21 Мөнхүү улиран тохиох дор гучин нэгдүгээр он улирч одов, мөн Их Эзэнд зөвхөн цөөн хэд нь хөрвүүлэгдэв; харин хөрвүүлэгдсэн болгон нь өөрсдийн итгэсэн түүнд, Есүс Христэд байсан Бурханы Сүнс мөн хүчээр зочлогдсоноо уг хүмүүст үнэхээр харуулсан болой.

22 Мөн чөтгөрүүд зайлуулагдав, мөн өвчин болон шаналлаасаа эдгээгдсэн болгон, Бурханы Сүнсээр тэд нөлөөлөгдсөн мөн эдгээгдсэнийг уг хүмүүст үнэхээр мэдүүлжээ; мөн тэд тэмдгүүдийг түүнчлэн үзүүлж мөн хүмүүсийн дунд зарим гайхамшгуудыг үйлдсэн бөлгөө.

23 Ийн гучинхоёрдугаар он түүнчлэн улирч одов. Мөн гучин гуравдугаар оны эхэнд Нифай хүмүүст тунхаглаж; мөн тэрбээр тэдэнд наманчлал хийгээд нүглүүдийн ангижралыг номлов.

24 Эдүгээ наманчлалд авчрагдсан тэднээс “баптисм хүртээгүй нэг нь ч байсангүйг

17a су Хүч.
18a 2 Ниф. 33:1;
Алма 4:19.

19a су Сүнс—Муу
ёрын сүнснүүд.
20a 3 Ниф. 8:1.

24a су Баптисм,
Баптисм хүртээх.

та нар түүнчлэн санаасай хэмээнэ би.

25 Тиймийн тул, тэдэнд ирэх бүгд нь баптисм хүртээхийн тулд энэхүү тохинуулалд Нифайгаар томилогдсон эрчүүд байлаа; мөн энэ нь Бурханы өмнө, мөн уг хүмүүст, тэд наманчилсан мөн “нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авсны гэрч мөн нотолгоо байв.

26 Мөн энэ оны эхэнд наманчлалд хүргэн баптисм хүртсэн нь олон байв; мөн ийн жилийн ихэнх хэсэг улирч одов.

БҮЛЭГ 8

Их салхи, газар хөдлөлт, түймэр, салхин хүрд, мөн байгалийн гамшигууд Христийн цовдлуулалтыг гэрчлэв—Олон хүмүүс устгагдав—Уг нутгийг гурван хоногийн турш харанхуй бүрхэв—Үлдсэн тэд хувь заяандаа гишүүдав. Ойролцоогоор мэ 33–34 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор бидний цэдгийн дагуу, мөн бидний цэдэг үнэн болохыг бид мэднэ, учрыг болгоогтун, уг цэдгийг хөтөлсөн тэр нь шударга хүн байв—учир нь тэрбээр Есүсийн нэрээр олон гайхамшиг үнэхээр үйлдсэн бөлгөө; мөн тэрбээр, алдсаасаа өчүүхэн хэсэг бүр нь цэвэрлэгдээгүй

аваас Есүсийн “нэрээр”^б гайхамшиг үйлдэж чадах ямар ч хүн үгүй билээ—

2 Мөн эдүгээ улиран тохиох дор, бидний цаг үеийг тооцоолохдоо энэ хүнээр алдаа хийгдээгүй бол, “гучин гуравдугаар он тийн улирч одсон байв;

3 Мөн лемен үндэстэн, бошиглогч Самуелаар өгөгдсөн байсан тэмдгийг, тийм ээ, уг нутгийн гадаргуу дээр гурав хоногийн турш “харанхуй байх тэр цагийг хүмүүс маш ихээр идэвхийлэн харж эхлэв.

4 Мөн ийм олон “тэмдэг өгөгдсөн хэдий ч, хүмүүсийн дунд агуу эргэлзээ хийгээд сөргөлдөөнүүд байж эхлэв.

5 Мөнхүү улиран тохиох дор гучин дөрөвдүгээр онд, эхний сард, уг сарын дөрөв дэх өдөр, бүх нутагт урьд хожид мэдэгдэж байгаагүй тийм нэгэн их шуурга босов.

6 Мөн түүнчлэн агуу хийгээд аймшигт их салхи байв; мөн аймшигт “аянга бууж, үүний хэрээр энэ нь бүхэл газар дэлхийг хоёр хэсэг хуваах гэж байгаа мэт”^б сэгсрэв.

7 Мөн бүх нутагт хэзээ ч үзэгдэж байгаагүй тийм үлэмж хурц цахилгаан цахив.

8 Мөн Зарахемла “хот түймэрт шатаж эхлэв.

9 Мөн Моронай хот тэнгисийн гүнд живж, мөн оршин суугчид нь живж үхэв.

25а С ба Г 20:37.

су Нүглүүдийн ангижрал.

8 1а Үйлс 3:6; Иаков 4:6.

б 3 Ниф. 7:19–20;

Морм. 9:18–19.

2а 3 Ниф. 2:8.

3а 1 Ниф. 19:10;

Хил. 14:20, 27;

3 Ниф. 10:9.

4а су Цовдлуулалт.

6а 1 Ниф. 19:11;

Хил. 14:21.

б Мат. 27:45, 50–51.

8а 4 Ниф. 1:7–8.

10 Мөн Моронайха хотын дээр газар зөөгдсөнөөс, хотын оронд агуу том уул байх болов.

11 Мөн өмнөд хэсгийн нутагт агуу хийгээд аймшигт устгал байв.

12 Гэвч болгоогтун, умардын нутагт илүү агуу хийгээд аймшигт устгал байв; учрыг болгоогтун, уг нутгийн бүх гадаргуу өөрчлөгдөв, шуурга мөн салхин хүрд, мөн аянга болон цахилгаан, мөн бүх газар үлэмж агуу ихээр хөдөлсний улмаас болой;

13 Мөн “их хөлийн замууд хагарч, мөн толигор замууд эвдэрч, мөн олон тэгш газар олон товон болжээ.

14 Мөн олон агуу хийгээд алдартай хотууд “живж, мөн олон нь шатаагдаж, мөн олон нь сэгсрэгдэж, барилгууд нь газарт унах хүртэл, мөн оршин суугчид нь эрсдэж, мөн уг газрууд эзгүйрэн орхигдов.

15 Мөн үлдэж хоцорсон зарим хотууд байлаа; гэвч эвдрэл нь үлэмж агуу байж, мөн тэдний дотор эрсэдсэн нь олон байв.

16 Мөн салхин хүрдэнд хийсэн одсон зарим нь байв; мөн тэдний хийсэн одсоныг гэдгийг тэд мэдэхээс бус, тэдний хааш одсоныг нэг ч хүн мэдэхгүй байв.

17 Мөн тийн бүхэл газар дэлхийн гадаргуу, шуурга, мөн аянга, мөн цахилгаан, мөн

газар хөдлөлтүүдийн улмаас хэлбэр нь алдагдсан байв.

18 Мөн болгоогтун, “хаднууд хоёр хэсэгт цуурч хагарав; тэдгээр нь бүх л газар дэлхийн гадаргуу дээр хагарав, үүний хэрээр тэдгээр нь хагарсан хэлтэрхийнүүд болж, мөн үе давхаргуудад мөн хагархайд, уг нутгийн бүх гадаргуу дээр хэвтэх болов.

19 Мөнхүү улиран тохиох дор аянга, мөн цахилгаан, мөн шуурга, мөн их салхи, мөн газар хөдлөлтүүд зогсоход — учир нь болгоогтун, тэдгээр нь барагцаалбал гурван цагийн турш үргэлжлэв; мөн илүү хугацаатай байсан хэмээн заримаар нь хэлэгдэв; гэсэн хэдий ч, эдгээр бүр агуу хийгээд аймшигт зүйлүүд барагцаалбал “гурван цагийн хугацаанд болов — мөн тэгэхэд болгоогтун, уг нутгийн гадаргуу дээр харанхуй байв.

20 Мөнхүү улиран тохиох дор өтгөн харанхуй нь уг нутгийн бүх гадаргуу дээр байв, үүний хэрээр үүний үхээгүй байсан оршин суугчид харанхуйн “мананг” мэдрэхүйц байв;

21 Мөн уг харанхуйн учир ямар ч гэрэл, лаа ч, бас бамбар ч байх аргагүй байлаа; бас сайн мөн үлэмж хуурай модоор ч гал асаагдах аргагүй байв, иймээс ямар ч гэрэл огт байх аргагүй байлаа;

22 Мөн ямар ч гэрэл, бас

13a Хил. 14:24;
3 Ниф. 6:8.
14a 1 Ниф. 12:4.

18a Хил. 14:21–22.
19a Лук 23:44.
20a 1 Ниф. 12:5; 19:11.

б Ег. 10:21–22.

түүдэг, бас сүүмэлзэх төдий гэрэл ч, бас нар, бас сар, бас одод ч харагдахгүй байв, учир нь уг нутгийн гадаргуу дээрх харанхуйн манан тийм агуу байв.

23 Мөнхүү улиран тохиох дор энэ нь “гурав хоног үргэлжилснээс тэнд ямар ч гэрэл харагдахгүй байв; мөн агуу гашуудал мөн гаслан мөн уйлаан бүх хүмүүсийн дунд үргэлжлэн байв; тийм ээ, хүмүүсийн ёлон гаслах нь агуу байв, тэдний дээр ирсэн тэрхүү харанхуй нь мөн агуу устгалын улмаас болой.

24 Мөн нэг газар уйлж, өгүүлсэн нь: Ай энэ агуу хийгээд гамшигт өдрийн өмнө бид наманчилсан болоосой, мөн тэгсэн бол ах дүүс маань хэлтрүүлэгдсэн байх сан, мөн тэд агуу хот “Зарахемлад шатаагдахгүй байх сан билээ хэмээн тэдний хэлэх нь сонсогдов.

25 Өөр нэг газар уйлж мөн гашуудаж, өгүүлсэн нь: Ай энэ агуу хийгээд аймшигт өдрийн өмнө бид наманчлан, мөн бошиглогчдыг хөнөөж мөн чулуугаар шидээгүй, мөн тэднийг зайлуулаагүй ч болоосой; тэгсэн бол ээжүүд маань мөн хонгорхон охид минь, мөн хүүхдүүд маань хэлтрүүлэгдсэн байх сан, мөн агуу хот Моронайхад булагдахгүй байх сан гэх нь сонсогдов. Мөн тийн хүмүүсийн гаслан агуу хийгээд аймшигтай байв.

БҮЛЭГ 9

Харанхуйд, Христийн дуу хоолой тэдний өөрсдийнх нь ёс бусын улмаас олон хүн мөн хотуудын устгалыг тунхаглав—Тэрбээр түүнчлэн өөрийн бурханлиг чанарыг тунхаглаж, Мосегийн хууль гүйцэлдсэнийг зарлаж, мөн хүмүүнийг түүнд ирж аврагдахыг урив. Ойролцоогоор мэ 34 он.

Мөнхүү улиран тохиох дор газар дэлхийн бүх оршин суугчдын дунд, энэ нутгийн бүх гадаргуу дээр нэгэн “дуу хоолой сонсогдож, чангаар ярьсан нь:

2 Ай халаг, энэ хүмүүст халаг, халаг; тэд наманчлахгүй аваас бүх газар дэлхийн оршин суугчдад “халаг; учир нь, миний хүмүүсийн хонгорхон хөвгүүд мөн охидын алагдагсдын учир чөтгөр⁶ хөхөрч, мөн түүний элчүүд баясах ажгуу; мөн тэдний унасан нь алдас мөн жигшүүрт хэргүүдийнх нь учир болой!

3 Болгоогтун, агуу хот Зарахемлаг, мөн оршин суугчдыг нь би түймэрт шатаасан.

4 Мөн болгоогтун, тэр агуу хот Моронайг би тэнгисийн гүнд живүүлж, мөн оршин суугчдыг нь живж үхэх болгосон.

5 Мөн болгоогтун, тэдний алдсууд хийгээд жигшүүрт хэргүүдийг өөрийн нүүрнээс далд оруулахаар, бошиглогчдын болон гэгээнтнүүдийн цус тэдний эсрэг надад

хойшид ирэхгүй байхын тулд агуу хот Моронайхаг, мөн түүний оршин суугчдыг нь би газраар хучсан.

6 Мөн болгоогтун, Гилгалын хотыг би булагдах болгож, мөн оршин суугчдыг нь газрын гүнд булшлагадахаар болгосон;

7 Тийм ээ, мөн Онаиха хот мөн түүний оршин суугчид мөн Мокумын хот мөн түүний оршин суугчид, мөн Иерусалимын хот мөн түүний оршин суугчдыг; мөн тэдний алдсууд хийгээд жигшүүрт хэргүүдийг нүүрнээсээ далд оруулан нуухын тулд, бошиглогчид болон гэгээнтнүүдийн цус тэдний эсрэг хойшид надад ирэхгүйн тулд, тэдгээрийн оронд “ус байхаар болгосон би.

8 Мөн болгоогтун, Гадиандайн хот, мөн Гадиомнагийн хот, мөн Иаковын хот, Гимгимнагийн хот, эдгээр бүгдийг булагдах болгосон би, мөн түүний оронд “толгод мөн хөндийнүүд болгосон; мөн тэдний ёс бус хийгээд жигшүүрт хэргүүдийг нүүрнээсээ далд оруулахын тулд, бошиглогчдын болон гэгээнтнүүдийн цус тэдний эсрэг хойшид надад ирэхгүй байхын тулд оршин суугчдыг нь газрын гүнд булшилсан би.

9 Мөн болгоогтун, хаан Иаковын хүмүүсийн оршин суусан агуу хот Иаковогафыг тэдний “нууц аллагууд мөн

бүлэглэлийн учир, бүх газар дэлхийн бүхий л ёс бусаас илүү, тэдний нүглүүд мөн ёс бусынх нь учир түймэрт шатаахаар болгосон би; учир нь миний хүмүүсийн амар амгаланг мөн уг нутгийн засгийн газрыг ⁶устгасан нь тэд болой; тиймийн тул тэднийг нүүрнээсээ далд оруулан устгахын тулд, бошиглогчид болон гэгээнтнүүдийн цус тэдний эсрэг хойшид надад ирэхгүйн тулд тэднийг шатаагдах болгосон би.

10 Мөн болгоогтун, Леменийн хот, мөн Жошийн хот, мөн Гадын хот, мөн Кишкүменийн хотыг, мөн тэдгээрийн оршин суугчдыг бошиглогчдыг зайлуулсан, мөн тэдний жигшүүрт хэргүүдийнх нь талаар тэдэнд тунхаглуулахаар миний илгээсэн тэднийг чулуугаар шидсэн ёс бусынх нь учир түймэрт шатаагдах болгосон би.

11 Мөн эдгээр бүгдийг тэд зайлуулснаас тэдний дунд зөв шударгыг үйлдэгсэд үгүй байсан учир, тэдний ёс бус хийгээд жигшүүрт хэргүүд миний нүүрнээс далд орохын тулд, тэдний дунд миний илгээсэн бошиглогчид болон гэгээнтнүүдийн цус ⁷газраас тэдний эсрэг надад хашгирахгүй байж болохын тулд би доош ⁶галыг илгээж мөн тэднийг устгасан.

12 Мөн “олон агуу устгалуудыг, мөн энэ хүмүүсийн дээр,

7а Езек. 26:19.

8а 1 Ниф. 19:11.

9а Хил. 6:17–18, 21.

б Мозая 12:8.

11а Эхл. 4:10.

б Хаад. дэд 1:9–16;

Хил. 13:13.

12а 3 Ниф. 8:8–10, 14.

тэдний ёс бус мөн жигшүүрт хэргүүдийнх нь учир энэ нутагт ирэхээр болгосон би.

13 Тэднээс илүү зөв шударга байснаас, Ай “хэлтрүүлэгдсэн та нар бүгд, эдүгээ би та нарыг ^бэдгээж болохын тулд та нар надад эргэн ирж, мөн нүглүүдээ наманчилж, мөн хөрвүүлэгдэхгүй гэж үү?

14 Тийм ээ, үнэнээр би та нарт хэлнэ, хэрэв та нар надад “ирэх аваас та нар ^бмөнх амьдралыг авах болно. Болгоогтун, миний “нигүүлслийн мутар та нарын зүг сунгаастай байна, мөн ирэх хэнийг боловч, түүнийг би хүлээн авах болно; мөн надад ирэх тэд адислагдсан болой.

15 Болгоогтун, би бол Бурханы Хүү Есүс Христ бөлгөө. Би тэнгэр ба газрыг, мөн тэдгээрийн дээрх бүх зүйлийг “бүтээсэн билээ. Би эхлэлээс Эцэгтэй хамт байсан. ^бБи Эцэгт буй, мөн Эцэг надад буй; мөн Эцэг нэрээ надаар алдаршуулсан болой.

16 Би өөрийнхөндөө ирсэн, гэтэл өөрийнхөн маань намайг “хүлээн авсангүй. Мөн миний ирэлтийн талаарх судрууд гүйцэлдсэн болой.

17 Мөн намайг хүлээн авсан болгонд, Бурханы хөвгүүд болохыг би тэдэнд “зөвшөөрсөн; мөн бүр миний нэрэнд итгэх болгонд би зөвшөөрөх болно, учир нь болгоогтун, надаар ^бгэтэлгэл ирдэг, мөн надаар “Мосегийн хууль гүйцэлдсэн бөлгөө.

18 Би бол дэлхийн “гэрэл ба амь. Би бол ^бАльфа ба Омега, эхлэл ба төгсгөл.

19 Мөн та нар “цаашид цус урсган надад өргөл өргөхгүй; тийм ээ, та нарын тахилууд мөн хайлах өргөл тань зогсоогдох болно, учир нь би та нарын тахилууд мөн хайлсан өргөлүүдээс тань алийг нь ч хүлээн авахгүй.

20 Мөн та нар харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийг надад “өргөл болгон өргөх болно. Мөн харууссан зүрх гэмшсэн сэтгэлтэйгээр надад ирэх хэнд боловч, түүнд би галаар мөн Ариун Сүнсээр баптисм хүртээнэ, бүр леменчүүдийн хөрвүүлгийн үе дэх надад итгэх тэдний итгэлийн учир, тэд галаар мөн Ариун Сүнсээр ^ббаптисм хүртсэн, бөгөөд үүнийг тэд мэдээгүй билээ.

21 Болгоогтун, дэлхийнхэнд гэтэлгэл авчрахаар, дэлхийнх-

13a 3 Ниф. 10:12.

б Иер. 3:22;

3 Ниф. 18:32.

14a 2 Ниф. 26:24–28;

Алма 5:33–36.

б Иохан 3:16.

в Алма 19:36.

15a Иохан 1:1–3;

Кол. 1:16; Хил. 14:12;

Ифер 4:7;

С ба Г 14:9.

б Иохан 17:20–22;

3 Ниф. 11:27; 19:23, 29.

16a Иохан 1:11;

С ба Г 6:21.

17a Иохан 1:12.

су Хүмүүн,

Хүмүүс—Хүн,

Тэнгэрлэг Эцэгтэй

адил болох

боломж; Бурханы

хөвгүүд охид.

б су Гэтэлгэх,

Гэтэлгэгдэх,

Гэтэлгэл.

в 3 Ниф. 12:19, 46–47; 15:2–9.

18a су Гэрэл, Христийн гэрэл.

б Илч. 1:8.

су Альфа ба Омега.

19a Алма 34:13.

20a 3 Ниф. 12:19;

С ба Г 20:37.

б 2 Ниф. 31:13–14.

нийг нүглээс нь аврахаар би дэлхийнхэнд ирсэн бөлгөө.

22 Тиймийн тул, “наманчилж мөн бяцхан ^бхүүхдийн адил надад ирэх хэнийг боловч, би түүнийг хүлээн авах болно, учир нь Бурханы хаант улс бол ийм хүмүүсийнх юм. Болгоогтун, ийм хүмүүсийн төлөө би ^аамиа өгч, мөн үүнийгээ буцаан авсан юм; тиймийн тул наманчил, мөн дэлхийн хязгаарууд та нар надад ир, мөн аврагдагтун.

БҮЛЭГ 10

Уг нутагт олон цагийн турши нам гүм байв—Эм тахиа дэгдээхийнүүдээ цуглуулдаг шиг өөрийн хүмүүсийг цуглуулна гэж Христийн дуу хоолой амлав—Хүмүүсийн илүү зөв шударга хэсэг нь хадгалагдан үлддэг. Ойролцоогоор мэ 34 он.

Мөн эдүгээ болгоогтун, улиран тохиох дор уг нутгийн бүх хүмүүс эдгээр үгсийг сонсож, мөн үүнийг үзсэн болой. Мөн эдгээр үгсийн дараа уг нутагт олон цагийн туршид нам гүм байв;

2 Учир нь уг хүмүүсийн гайхашрал агуу байснаас тэд эрсэдсэн садан төрлөө алдсандаа халаглах мөн гаслахаа болив; тиймийн тул бүх нутагт олон цагийн туршид нам гүм байв.

3 Мөнхүү улиран тохиох дор уг хүмүүст дахин нэгэн дуу хоолой ирж, мөн бүх хүмүүс сонсож, мөн үүний гэрч болов, тэр нь өгүүлсэн нь:

4 Ай унасан эдгээр “агуу их хотын хүмүүс, Иаковын удмынхан болох, тийм ээ, Израилын угсаа болох та нар, эм тахиа дэгдээхийнүүдээ далавчин дороо цуглуулдаг шиг би та нарыг хичнээн ч удаа цуглуулж мөн ^басарсан билээ.

5 Мөн тэрчлэн, тахиа дэгдээхийнүүдээ далавчин дороо цуглуулдаг шиг би та нарыг хичнээн ч удаа цуглуулахсан хэмээв, тийм ээ, Ай Израилын угсааны унасан хүмүүс та нар; тийм ээ, Ай Израилын угсааны хүмүүс та нар, унасан та нар мөн түүнчлэн Иерусалимд орших та нар; тийм ээ, тахиа дэгдээхийнүүдээ цуглуулдаг шиг би та нарыг “хичнээн ч удаа цуглуулахсан хэмээв, мөн та нар цугласангүй.

6 Ай миний “хэлтрүүлсэн Израилын угсаа та нар, хэрэв та нар наманчилж мөн ^бзүрх сэтгэлийнхээ бүрэн тэмүүлээр надад ^аэргэж ирэх аваас, тахиа далавчин дороо дэгдээхийнүүдээ цуглуулдаг шиг хичнээн ч удаа би та нарыг цуглуулах билээ.

7 Гэвч эс тэгвээс, Ай Израилын угсаа, та нарын оршин

22а су Наманчлах,
Наманчлал.
б Марк 10:15;
Мозая 3:19;
3 Ниф. 11:37–38.

в Иохан 10:15–18.
10 4а 3 Ниф. 8:14.
б 1 Ниф. 17:3.
5а Мат. 23:37;
С ба Г 43:24–25.

6а 3 Ниф. 9:13.
б Езек. 36:26.
в 1 Сам. 7:3;
Хил. 13:11;
3 Ниф. 24:7.

буй газрууд тань эцэг өвгөд-тэй чинь хийсэн “гэрээний гүйцэтгэлийн цагийг хүртэл эзгүй байх болно.

8 Мөн эдүгээ улиран тохиох дор уг хүмүүс эдгээр үгсийг сонссоныхоо дараа, болгоогтун, тэд садан төрөл мөн найз нөхдөө алдсаныхаа улмаас дахин уйлж мөн гасалж эхлэв.

9 Мөнхүү улиран тохиох дор гурван өдөр тийн улирч одов. Мөн энэ нь өглөө байж, мөн уг нутгийн гадаргуу дээрээс “харанхуй сарниж, мөн газар чичрэхээ больж, мөн хаднууд цуурахаа больж, мөн аймаар ёолон гаслах нь зогсож, мөн бүх үймээн шуугианууд нь улирч одов.

10 Мөн газар дахин нэгдэн нийлснээс, энэ нь тэсэж өнгөрөв; мөн амь хэлтрүүлэгдсэн хүмүүсийн гашуудах нь, мөн уйлах нь, мөн ёолон гаслах нь зогссон болой; мөн тэдний гашуудах нь баясалд, мөн тэдний халаглах нь магтан дуулахад мөн Их Эзэн Есүс Христ, өөрсдийн Гэтэлгэгчид талархахад шилжсэн байв.

11 Мөн бошиглогчдоор яригдсан судрууд өдийг хүртэл “гүйцэлдэв.

12 Мөн аврагдсан нь уг хүмүүсийн “илүү зөв шударга нь байв, мөн бошиглогчдыг хүлээн авч мөн тэднийг чулуугаар шидээгүй нь тэд

байв; мөн гэгээнтнүүдийн цусыг урсгаагүй нь тэд байв, хэлтрүүлэгдсэн тэд буюу—

13 Мөн тэд хэлтрүүлэгдсэн мөн живээгүй мөн газарт булагдаагүй; мөн тэд тэнгисийн гүнд живүүлэгдсэнгүй; мөн тэд түймрээр шатаагдсангүй, бас тэд дарагдаж мөн үхтлээ няцлагдсангүй; мөн тэд хуй салхинд хийсч одсонгүй; бас тэд утаан мөн харанхуйн мананд автагдсангүй.

14 Мөн эдүгээ, унших хэн боловч тэр нь ойлгог; судрууд бүхий тэр нь тэдгээрийг “судлаг, мөн түймрээр, мөн утаагаар, мөн их салхиар, мөн хуйгаар, мөн тэднийг авах газрын “ангалаар эдгээр бүх үхлүүд хийгээд устгалууд, мөн эдгээр бүх зүйл ариун бошиглогчдын олных нь бошиглолуудыг гүйцэлдүүлсэн эсэхийг харж мөн болгоог.

15 Болгоогтун, би та нарт хэлнэ, Тийм ээ, олон нь Христийн ирэлтийн үед эдгээр зүйлийг гэрчилж, мөн тэд эдгээр зүйлсийг гэрчилсэн учир “хөнөөгдсөн болой.

16 Тийм ээ, бошиглогч “Зинос эдгээр зүйлийг гэрчилсэн, мөн түүнчлэн Зинок эдгээр зүйлийн талаар ярьсан, учир нь тэдний үр удмын үлдэгдэл болох бидний талаар онцгойлон гэрчилсэн болой.

7a су Гэрээ.
9a 3 Ниф. 8:19.
11a Үйлс 3:18–20.
12a 2 Ниф. 26:8;
3 Ниф. 9:13.

14a су Судрууд—
Судруудын үнэ
цэнэ.
б 1 Ниф. 19:11;
2 Ниф. 26:5.

15a су Санаатайгаар
алах, Санаатай
аллага.
16a Хил. 8:19–20.

17 Болгоогтун, бидний өвөг Иаков түүнчлэн Иосефын үр удмын “үлдэгдлийн талаар гэрчилсэн билээ. Мөн болгоогтун, бид Иосефын үр удмын үлдэгдэл биш гэж үү? Мөн бидний тухай гэрчлэх эдгээр зүйлүүд, бидний өвөг Лихай Иерусалимаас авчирсан гуулин ялтсууд дээр бичиглэгдсэн байгаа бус уу?

18 Мөнхүү улиран тохиох дор гучин дөрөвдүгээр оны төгсгөлд, болгоогтун, хэлтрүүлэгдсэн Нифайн хүмүүс, мөн түүнчлэн хэлтрүүлэгдсэн леменчүүд гэж нэрлэгдсэн, тэдэнд агуу халамжууд үзүүлэгдсэнийг, мөн агуу адислалууд тэдний тэргүүн дээр цутгагдсаныг, үүний хэрээр Христ тэнгэрт “дээшилсний дараахан тэрбээр үнэхээр тэдэнд өөрийгөө үзүүлснийг би та нарт харуулах болно —

19 Өөрийн биеийг тэдэнд “үзүүлж, мөн тэдэнд тохинуулсан бөлгөө; мөн түүний тохинууллын шастир цаашид өгөгдөх болно. Тиймийн тул одоогоор би үгсээ төгсгөл болгоё.

Олон хүн Өгөөмөр нутагт нэгдэн цугларахад, Есүс Христ өөрийгөө Нифайн хүмүүст үзүүлж, мөн тэдэнд тохинуулсан болой; мөн энэ маягаар тэрбээр тэдэнд өөрийгөө үзүүлэв.

11-ээс 26 дугаар бүлэгт агуулагдав.

БҮЛЭГ 11

Эцэг өөрийн Хайрт Хүүгийн тухай гэрчлэв—Христ хурчирэн мөн өөрийн цагаатгалыг тунхаглав—Хүмүүс түүний гардахь мөн хөл дэх мөн хажуугийн шархны ормыг тэмтэрч үзэв—Тэд Хосанна хэмээн хашиграв—Тэрээр баптисмын маяг мөн аргыг зааварчлан өгөв—Зөрчилдөөний сүнс бол чөтгөрөөс юм—Хүмүүн итгэж мөн баптисм хүртэж мөн Ариун Сүнс хүлээн авах нь Христийн сайн мэдээ бөлгөө. Ойролцоогоор мэ 34 он.

Мөнхүү эдүгээ улиран тохиох дор Нифайн хүмүүсээс, Өгөөмөр нутаг дахь ариун сүмийн эргэн тойронд нэгдэн цугларцгаасан их олон хүмүүс байв; мөн тэд болсон тэрхүү агуу хийгээд гайхамшигт өөрчлөлтийг нэг нэгэндээ заан үзүүлж, мөн “гайхаж бас гайхширан нэг нэгэнтэйгээ ярьж байв.

2 Мөн түүний үхлийн талаар өгөгдсөн “тэмдэг хамаарах энэхүү Есүс Христийн тухай тэд түүнчлэн ярилцаж байлаа.

3 Мөнхүү улиран тохиох дор тэд тийн бие биентэйгээ ярилцаж байх хооронд, тэд тэнгэрээс ирэх мэт нэгэн “дуу хоолойг сонсов; мөн тэд эргэн тойрондоо хараа бэлчээв, учир нь тэд сонссон тэр дуу хоолойг ойлгосонгүй; мөн энэ нь хүйтэн хөндий дуу хоолой, бас чанга дуу хоолой

17a 2 Ниф. 3:4–5;
Алма 46:24;
3 Ниф. 5:23–24.

18a Үйлс 1:9–11.
19a 3 Ниф. 11:12–15.
11 1a 3 Ниф. 8:11–14.

2a Хил. 14:20–27.
3a Дэд хууль 4:33–36;
Хил. 5:29–33.

ч бус байв; гэсэн хэдий ч, энэ нь ^бнамуухан дуу хоолой байсан ч гэсэн, сонссон тэдний биенийх нь төвд нэвтрэн орж, үүний хэрээр салгалаагүй тэдний биеийн нэг ч хэсэг байсангүй; тийм ээ, энэ нь тэдэнд чухам бодгальд нь нэвтрэн орж, мөн тэдний зүрх сэтгэлийг шатах мэт болгож байв.

4 Мөнхүү улиран тохиох дор тэд уг дуу хоолойг дахин сонсоод мөн тэд үүнийг ойлгосонгүй.

5 Мөн гурав дахь удаагаа тэд уг дуу хоолойг дахин сонсож, мөн үүнийг сонсохоор соноороо дэлгэв; мөн тэдний харц дуу гарсан зүгт чиглэв; мөн тэд тэрхүү дуу хоолой ирсэн тэнгэрийн зүг тууштайгаар ажиглаж байв.

6 Мөн болгоогтун, гурав дахь удаад нь тэд сонссон тэр дуу хоолойгоо ойлгосон болой; мөн энэ нь тэдэнд хэлэв:

7 Миний “Хайрт Хүүг, ^бминий ихэд таалсан түүнийг, би өөрийнхөө нэрийг алдаршуулсан түүнийг болгоогтун— та нар түүнийг анхааран сонсогтун.

8 Мөнхүү улиран тохиох дор, тэд ойлгоод тэнгэрийн зүг дахин хараа чиглүүлэв; мөн болгоогтун, тэд тэнгэрээс бууж ирж буй Хүнийг “үзэв; мөн тэрээр цагаан орхимжоор хувцаслагдсан байв;

мөн тэрээр бууж ирээд мөн тэдний дунд зогсов; мөн бүх цугларагсдын харц түүн дээр тусаж, мөн тэд бүр нэг нэгэндээ ч ам нээж зүрхэлсэнгүй, мөн энэ нь чухам ямар учиртайг мэдсэнгүй, учир нь тэдэнд үзэгдсэн нь тэнгэр элч хэмээн тэд боджээ.

9 Мөнхүү улиран тохиох дор тэр мутраа урагш сунгаад мөн хүмүүст ярьж, өгүүлсэн нь:

10 Болгоогтун, би бол дэлхийд ирэх болно хэмээн бошиглогчдын гэрчилсэн тэр Есүс Христ.

11 Мөн болгоогтун, би бол дэлхийн “гэрэл ба амь; мөн би Эцэгийн надад өгсөн гашуун ^баяганаас ууж, мөн эхлэлээс бүх зүйлийн хувьд Эцэгийн “тааллыг хүлцэж, дэлхийнхний нүглүүдийг өөр дээрээ ‘авснаар Эцэгийг алдаршуулсан билээ.

12 Мөнхүү улиран тохиох дор Есүс эдгээр үгсийг ярьсны дараа бүх цугласан олон газарт унав; учир нь Христ тэнгэрт дээшлэн одсоныхоо дараа тэдэнд өөрийгөө үзүүлнэ гэсэн нь тэдний дунд “бошиглогчсоныг тэд санацгаасан аж.

13 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн тэдэнд ярьж, хэлсэн нь:

14 Босогтун мөн хавирган талын сорвинд минь та нар “гараа хүргэж болохын тулд, мөн түүнчлэн миний мутар

3б Хаад, дээд 19:11–13;

С ба Г 85:6.

7а Мат. 3:17; 17:5;

ИС—Т 1:17.

б 3 Ниф. 9:15.

8а 1 Ниф. 12:6;

2 Ниф. 26:1.

11а су Гэрэл, Христийн гэрэл.

б Мат. 26:39, 42.

в Марк 14:36;

Иохан 6:38;

С ба Г 19:2.

г Иохан 1:29;

С ба Г 19:18–19.

12а Алма 16:20.

14а Иохан 20:27.

дахь мөн хөлөн дэх хадаасны ормуудыг та нар ⁶тэмтэрч болохын тулд над дээр нааш ирэгтүн, тиймээс би бол ⁶Израилын Бурхан, мөн бүх дэлхийн Бурхан, мөн ⁷дэлхийнхний нүглүүдийн төлөө егүүтгэгдсэнийг та нар мэдэж болно.

15 Мөнхүү улиран тохиох дор цугласан олон урагшилж, мөн гараа түүний хавирган талын сорвинд хүргэж, мөн түүний мутар дахь мөн түүний хөлөн дэх хадаасны ормуудыг тэмтэрч үзэв; мөн тэд үүнийг үйлдэж, бүгд очих хүртлээ нэг нэгээрээ явж, мөн нүдээрээ үзэж мөн гараараа тэмтэрч, мөн бошиглогчдоор ирэх “болно хэмээн бичигдсэн тэр нь мөн болохыг гарцаагүйгээр мэдэж мөн гэрчлэв.

16 Мөн тэд бүгд очоод мөн өөрсдөө үзэж, тэд нэгэн дуугаар хашгирч хэлсэн нь:

17 Хосанна! Бүхний Дээд Бурханы нэр алдаршиг! Мөн тэд Есүсийн хөлд доош унаж, мөн түүнийг “шүтэн бишрэв.

18 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр “Нифайд ярьж (учир нь Нифай цугласан олны дунд байв) мөн тэрбээр түүнд хүрч ирэхийг зарлиг болов.

19 Мөн Нифай босож мөн

очоод, мөн өөрийгөө Их Эзэний өмнө бөхийлгөн мөн түүний хөлийг үнсэв.

20 Мөн Их Эзэн түүнд босохыг зарлиг болов. Мөн тэрбээр босож мөн түүний өмнө зогсов.

21 Мөн Их Эзэн түүнд хэлэв: Намайг дахин тэнгэрт дээшлэн одоход энэ хүмүүст “баптисм хүртээх ⁶хүчийг би чамд өгье.

22 Мөн дахин Их Эзэн “бусад заримыг дуудаж, мөн тэдэнд нэгэн адилыг хэлжээ; мөн тэрбээр тэдэнд баптисм хүртээх хүчийг өгөв. Мөн тэрбээр тэдэнд хэлсэн нь: Энэхүү маягаар та нар баптисм хүртээх болно; мөн та нарын дунд ямар ч ⁶сөргөлдөөнүүд байх ёсгүй.

23 Та нарын “үгсийн дагуу нүглүүдээ наманчилж, мөн миний нэрээр баптисм хүртэхийг ⁶хүсэх хэнд боловч, энэхүү маягаар та нар тэдэнд баптисм хүртээх болно гэдгийг үнэнээр би та нарт хэлнэ— Болгоогтун, та нар доош явж мөн усанд ⁶зогсох болно, мөн миний нэрээр тэдэнд та нар баптисм хүртээх болно.

24 Мөн эдүгээ болгоогтун, эдгээр нь та нарын хэлэх тэрхүү үгс, тэднийг нэрээр нь дуудаж хэлэх нь:

146 Лук 24:36–39;

С ба Г 129:2.

в Иса. 45:3;

3 Ниф. 15:5.

г 1 Ниф. 11:6.

15а су Есүс Христ—

Христийн мөнх бус амьдралын дараах

ирэлт.

17а су Шүтэн бишрэв.

18а 3 Ниф. 1:2, 10.

21а су Баптисм,

Баптисм хүртээх.

б су Хүч.

22а 1 Ниф. 12:7;

3 Ниф. 12:1.

б 3 Ниф. 18:34.

23а 3 Ниф. 12:2.

б су Баптисм,

Баптисм хүртээх—

Баптисмд тэнцэх.

в 3 Ниф. 19:10–13.

25 Есүс Христээр надад “эрх мэдэл өгөгдсөн учир би ^бЭцэг, мөн Хүү, мөн Ариун Сүнсний нэрээр танд баптисм хүртээж байна. Амен.

26 Мөн тэгээд та нар тэднийг усанд “бүрэн дүрж, мөн уснаас буцаан гаргаж ирэх болно.

27 Мөн энэ маягийн дагуу миний нэрээр та нар баптисм хүртээх болно; учир нь болгоогтун, үнэнээр би та нарт хэлнэ, Эцэг, мөн Хүү, мөн Ариун Сүнс бол “нэг юм; мөн би Эцэгт буй, мөн Эцэг надад буй, мөн Эцэг бид хоёр нэг юм.

28 Мөн та нарт миний зарлиг болсны дагуу та нар тийн баптисм хүртээх болно. Мөн та нарын дунд өмнө нь байсан шиг ямар ч “сөргөлдөөн байх ёсгүй; бас өмнө нь байсан шиг сургаалын минь заалтуудын талаар та нарын дунд сөргөлдөөнүүд байх ёсгүй.

29 Учир нь үнэнээр, үнэнээр би та нарт хэлнэ, “зөрчилдөөний сүнстэй тэр нь надаас бус, харин зөрчилдөөний эцэг болох ^бчөтгөрөөс болой, мөн тэрбээр хүмүүний зүрх сэтгэлийг нэг нэгэндээ уурлан зөрчилдөхөд өдөөн хатгадаг.

30 Болгоогтун, хүмүүний

зүрх сэтгэлийг нэг нь нөгөөгийнхөө эсрэг уураар өдөөн хатгах нь миний сургаал бус; харин иймэрхүү зүйлүүд зайлуулагдах ёстой нь миний сургаал бөлгөө.

31 Болгоогтун, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, би та нарт “сургаалаа тунхаглах болно.

32 Мөн энэ бол миний “сургаал, мөн энэ бол Эцэгийн надад өгсөн тэрхүү сургаал билээ; мөн би Эцэгийн тухай ^бгэрчилж, мөн Эцэг миний тухай гэрчилж, мөн “Ариун Сүнс нь Эцэг бид хоёрын тухай гэрчилдэг; мөн наманчилж мөн надад итгэхийг Эцэг газар газрын бүх хүмүүст зарлиг болгодгийг би гэрчилж байна.

33 Мөн надад итгэсэн, мөн “баптисм хүртсэн хэн боловч, мөнхүү тэр нь ^баврагдах болно; мөн тэд бол Бурханы хаант улсыг ^бөвлөх хүмүүс юм.

34 Мөн надад итгэхгүй, мөн баптисм хүртэхгүй хэн боловч, яллагдах болно.

35 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, энэ бол миний сургаал, мөн Эцэгийн өмнөөс би үүнийг гэрчилнэ; мөн надад “итгэдэг хэн боловч

25a Мозая 18:13;
С ба Г 20:73.
су Баптисм, Баптисм хүртээх —Зөв эрх мэдэл.
б су Бурхан, Бурхан тэргүүтэн.
26a су Баптисм, Баптисм хүртээх—Умбуулах баптисм.
27a Иохан 17:20–22;
3 Ниф. 28:10;

Морм. 7:7;
С ба Г 20:28.
28a 1 Кор. 1:10; Ефес 4:11–14; С ба Г 38:27.
29a 2 Тиа. 2:23–24;
Мозая 23:15.
су Уруу таталт.
б исо, Ефес 4:26;
Мозая 2:32–33.
31a 2 Ниф. 31:2–21.
32a су Христийн Сургаал.

б 1 Иохан 5:7.
в 3 Ниф. 28:11;
Ифер 5:4.
33a Марк 16:16.
су Баптисм, Баптисм хүртээх нь—чухал шаардлага.
б су Аврал.
в су Селестиел алдар суу.
35a Ифер 4:12.

түүнчлэн Эцэгт итгэдэг; мөн түүнд миний тухай Эцэг гэрчилэх болно, учир нь тэрбээр түүнд ⁶галаар мөн “Ариун Сүнсээр зочлох болно.

36 Мөн тийн Эцэг миний тухай гэрчилдэг, мөн Ариун Сүнс түүнд Эцэг бид хоёрын тухай гэрчлэх болно; учир нь Эцэг, мөн Би, мөн Ариун Сүнс бол нэг юм.

37 Мөн тэрчлэн би та нарт хэлнэ, та нар наманчилж, мөн “бяцхан хүүхэд лугаа адил болж, мөн миний нэрээр баптисм хүртэх ёстой, эс бөгөөс та нар эдгээр зүйлийг ямар ч аргаар хүлээн авч чадахгүй.

38 Мөн тэрчлэн би та нарт хэлнэ, та нар наманчилж, мөн миний нэрээр баптисм хүртэж, мөн бяцхан хүүхэд лугаа адил болох ёстой, эс бөгөөс та нар Бурханы хаант улсыг ямар ч аргаар өвлөж чадахгүй.

39 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, энэ нь миний сургаал, мөн үүний дээр “барьж босгодог хэн боловч миний хадан дээр барьж босгоно, мөн тамын ⁶үүд тэднийг дийлэх нь үгүй.

40 Мөн эдүгээ үүнээс илүүг буюу дутууг тунхаглах мөн миний сургаал мэтээр түүнийг тогтоох хэн боловч, тэрхүү хүн хилэнцээс ирдэг, мөн миний хадан дээр барьж босгогдоогүй байдаг; харин

тэр “элсэн суурин дээр барьж босгодог мөн үер болж мөн тэдний дээр салхи нүдэхэд тиймийг нь хүлээн авахаар тамын хаалга нээлттэй байдаг.

41 Тиймийн тул, энэ хүмүүст очиж, мөн миний ярьсан үгсийг дэлхийн хязгааруудад тунхаглагтун.

БҮЛЭГ 12

Есүс Арванхоёрыг дуудаж мөн итгэмжлэл хүлээлгэв—Тэрбээр Уулан дээрх Номлолтой төстэйг нифайчуудад яриу—Тэрбээр Ерөөлүүдийг хэлэв—Түүний зааврууд дахь зүйлүүд Мосегийн хуулийг давж гарч, мөн орлов—Тэр түүний Эцэг төгсийн адил хүмүүн төгс байхыг зарлиг болгуулав—Матай бүлэгт 5-тай харьцуул. Ойролцоогоор мэ 34 он.

Мөнхүү улиран тохиох дор Есүс эдгээр үгийг Нифайд, мөн дуудагдсан тэдэнд яриад, (эдүгээ дуудагдаж, мөн баптисм хүртээх хүч болон эрх мэдлийг хүлээн авсан тэдний тоо нь “арванхоёр байв) мөн болгоогтун, тэр мутраа урагш цугларсан олонд сунгаж, мөн тэдэнд чанга дуугаар ярьж, өгүүлсэн нь: Та нарт тохинуулж, мөн та нарын зарц нар байхаар та нарын дундаас миний ⁶сонгосон эдгээр арванхоёрын үгсэд анхаарлаа хандуулах аваас та

35б 3 Ниф. 9:20; 12:2.

в су Ариун Сүнс.

37а Марк 10:15;

Лук 18:17;

Мозая 3:19;

3 Ниф. 9:22.

39а Мат. 7:24–29;

Хил. 5:12.

су Хад.

б 3 Ниф. 18:12–13.

40а 3 Ниф. 14:24–27.

12 1а 3 Ниф. 13:25.

б су Дуудах,

Бурханаас

дуудагдах,

Дуудлага.

нар “адислагдах болно; мөн тэд та нарт баптисм хүртээж болно хэмээн би хүчийг тэдэнд өгсөн бөлгөө; мөн та нар баптисм хүртсэний дараа, болгоогтун, би та нарт галаар мөн Ариун Сүнсээр баптисм хүртээх болно; тиймийн тул та нар намайг харж мөн би байдаг гэдгийг мэдсэний дараа, та нар надад итгэж мөн баптисм хүртвэл адислагдах болно та нар.

2 Мөн тэрчлэн, та нар намайг харж, мөн би байдаг гэдгийг мэддэгээ та нар гэрчлэх учир, та нарын үгсэд “итгэх тэд илүү адислагдах болно. Тийм ээ, үгсэд тань итгэх мөн даруу байдлын гүн уруу ^бирэх мөн баптисм хүртэх тэд адислагдах болно, учир нь тэд ^вгалаар мөн Ариун Сүнсээр зочлогдох болно, мөн нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авах болно.

3 Тийм ээ, надад “ирэх сүнсэндээ ^бядуу нь адислагдах болно, учир нь тэнгэрийн хаант улс бол тэднийх юм.

4 Мөн тэрчлэн, гашуудах тэд бүгд адислагдах болно, учир нь тэд тайвшруулагдах болно.

5 Мөн “хүлцэнгүй номхон нь

адислагдах болно, учир нь тэд ^бгазар дэлхийг өвлөх болно.

6 Мөн “зөв шударгын төлөө ^бөлсөж мөн “цангах тэд бүгд адислагдах болно, учир нь тэд Ариун Сүнсээр дүүргэгдэх болно.

7 Мөн “нигүүлсэнгүй нь адислагдах болно, учир нь тэд өршөөл нигүүлслийг олж авах болно.

8 Мөн зүрх сэтгэлдээ “цэвэр ариун бүгд нь адислагдах болно, учир нь тэд Бурханыг ^бхарна.

9 Мөн “энхийг сахигч бүгд адислагдах болно, учир нь тэд ^бБурханы хүүхдүүд хэмээн нэрлэгдэх болно.

10 Мөн миний нэрийн төлөө “хавчин гадуурхагдсан тэд бүгд адислагдах болно, учир нь тэнгэрийн хаант улс тэднийх юм.

11 Мөн надаас болж хүмүүс та нарыг доромжлох мөн хавчин гадуурхах мөн та нарын эсрэг гүтгэн бүхий л хилэнцтийг хэлэх үед та нар адислагдах болно.

12 Учир нь та нар агуу баясал мөн үлэмжийн баяр хөөртэй байх болно, учир нь тэнгэрт “шагнал тань агуу байх болно; учир нь та нарын өмнө

1в су Адислах, Адислагдах, Адислал.

2а С ба Г 46:13–14. су Итгэлтэй байх, Итгэл.

б Ифер 4:13–15.

в 3 Ниф. 11:35; 19:13.

3а Мат. 11:28–30.

б С ба Г 56:17–18.

су Даруу, Даруу байдал.

5а Ром 12:16;

Мозая 3:19.

су Номхон

дөлгөөн, Номхон

дөлгөөн байдал.

б су Газар дэлхий.

6а Сур. үгс 21:21.

б 2 Ниф. 9:51;

Инос 1:4.

в Иер. 29:13.

7а су Нигүүлсэнгүй, Нигүүлсэл.

8а су Цэвэр ариун,

Цэвэр ариун

байдал.

б С ба Г 93:1.

9а су Амар амгаланг

тогтоогч.

б су Бурханы хөвгүүд

охид.

10а С ба Г 122:5–9.

су Хавчин,

Хавчлага.

12а Ифер 12:4.

байсан бошиглогчдыг тэд тэгж хавчин үүнчлэн гадуурхсан билээ.

13 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, газар дэлхийн “давс байх үүргийг би та нарт өгдөг; гэвч хэрэв давс амтаа алдвал газар дэлхий юугаар давслагдах билээ? Уг давс түүнээс хойш, зайлуулагдаж мөн хүмүүний хөл дор дэвслэгдэхээс өөр юунд ч хэрэггүй байх болно.

14 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, энэ хүмүүсийн гэрэл байх үүргийг би та нарт өгнө. Толгойд дээр байрласан хот нууцлагдах аргагүй билээ.

15 Болгоогтун, хүмүүс “лаа асаагаад мөн үүнийгээ тогоон дор нуудаг бил үү? Үгүй ээ, харин лааны тавиур дээр тавьж, мөн энэ нь гэрт байгаа бүгдэд гэрэл өгдөг;

16 Тиймийн тул, тэд та нарын сайн ажлуудыг харж, тэгээд тэнгэр дэх Эцэгийг тань алдаршуулж болохын тулд “гэрэл тань энэ хүмүүсийн өмнө тийн туяаран гийг.

17 Хуулийг эсвээс бошиглогчдыг устгахаар намайг ирсэн гэж бүү бод. Би устгахаар ирсэн биш, харин гүйцэлдүүлэхээр билээ;

18 Учир нь үнэнээр би та нарт хэлнэ, уг “хуулиас нэг цэг, нэг жижиг зураас ч улирч одоогүй, харин энэ нь бүгд надаар гүйцэлдсэн билээ.

19 Мөн болгоогтун, та нар

надад итгэхийн тулд, мөн та нар нүглүүдээ наманчилж, мөн “харууссан зүрх гэмшсэн сэтгэлтэйгээр надад ирэхийн тулд би Эцэгийнхээ хууль болон зарлигуудыг та нарт өгсөн. Болгоогтун, та нарын өмнө зарлигууд байна, мөн “хууль нь гүйцэлдсэн билээ.

20 Тиймийн тул надад ирж мөн та нар аврагд; учир нь үнэнээр би та нарт хэлнэ, энэ цагт та нарт миний зарлигласан тэрхүү зарлигуудыг дагахаас бусдаар, та нар тэнгэрийн хаант улсад яавч орохгүй.

21 Энэ нь хуучин цагийн тэднээр хэлэгдсэнийг та нар сонссон, мөн энэ нь түүнчлэн та нарын өмнө бичигдсэн байна, чи “алах ёсгүй, мөн алсан хэн боловч, Бурханы шүүлтийн дор аюултай байдалд байх болно;

22 Гэвч би та нарт хэлнэ, ахдаа уурласан хэн боловч түүний шүүлтийн дор аюултай байдалд байх болно. Мөн ах дүүдээ, Хоосон толгой гэж хэлэх хэн боловч, шүүхэд та тагдах аюултай байдалд байх болно; мөн Чи мунхаг гэж хэлэх хэн боловч, галт тамын аюулд байх болно.

23 Тиймийн тул, хэрэв та нар надад ирэхийг өөрөөр хэлбэл надад ирэхийг хүсэвч мөн ах дүүд тань чиний эсрэг аливаа нэгэн буйг санах аваас—

24 Өөрийн замаар ах дүүдээ

13а С ба Г 101:39–40.

су Давс.

15а Лук 8:16.

16а 3 Ниф. 18:24.

18а су Мосегийн хууль.

19а 3 Ниф. 9:20.

су Харууссан зүрх.

б 3 Ниф. 9:17.

21а Ег. 20:13;

Мозая 13:21;

С ба Г 42:18.

очиж, мөн эхлээд ах дүүтэйгээ “эвлэрч, мөн тэгээд зүрх сэтгэлийнхээ бүх тэмүүлээр надад ирэгтүн, мөн би чамайг хүлээн авах болно.

25 Тэрээр чамайг ямар нэгэн үед дийлж, мөн чи шоронд хаягдах болуузай хэмээн өс-төнтэйгээ замаар явж байх-даа түүнтэй хурдхан эвлэр.

26 Үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, чи эцсийн синайныг төлсөн байх хүртлээ тэндээс гарч ирэх аргагүй болно. Мөн та нар шоронд байх зуураа бүр ганц “синайныг ч төлж чадна гэж үү? Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, Үгүй.

27 Болгоогтун, чи “садар самууныг үйлдэх ёсгүй хэмээн хуучин цагийн тэднээр бичигдсэн байдаг;

28 Гэвч би та нарт хэлнэ, “тачаадахын улмаас эмэгтэйг харсан хэн боловч, зүрх сэтгэлдээ аль хэдийн садар самууныг үйлдсэн байдаг.

29 Болгоогтун, та нар эдгээр зүйлийн нэгээхнийг ч “зүрх сэтгэлдээ оруулахыг хүлцэх ёсгүй хэмээх зарлигийг би та нарт өгье;

30 Учир нь та нар өөрсдөө эдгээр зүйлсээс татгалзсанаар та нар “загалмайгаа үүрэх нь тамд хаягдсанаас дээр байх болно.

31 Эхнэрээсээ салсан хэн боловч, эхнэртээ “салалтыг

гэрчилсэн бичиг өг хэмээн бичигдсэн байдаг.

32 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, “завхайрлын шалтгаанаас бусдаар эхнэрээсээ ^бсалах хэн боловч, түүнийг ^асадар самууныг үйлдэх болгосон хэрэг юм; мөн салсан эхнэртэй гэрлэх хэн - боловч садар самууныг үйлдсэн хэрэг юм.

33 Мөн тэрчлэн, чи хуурамчаар тангараглах ёсгүй нь бичигдсэн, харин Их Эзэний төлөөх “ам тангаргаа биелүүлэх ёстой.

34 Гэвч үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, “тангараг огт бүү тавь; бас тэнгэрээр ч бүү тангарагла, учир нь энэ бол Бурханы сэнтий юм;

35 Бас газар дэлхийгээр ч, учир нь энэ нь түүний хөлний гишгүүр бөлгөө;

36 Бас чи толгойгоороо ч бүү тангарагла, учир нь чи нэг үсийг ч хар эсвээс цагаан болгож чадахгүй;

37 Харин үг чинь Тийм ээ, тийм; Үгүй үгүй байг; учир нь эдгээрээс илүүгээр хэлэгдсэн нь юу боловч хилэнцэт бөлгөө.

38 Мөн болгоогтун, “нүдийг нүдээр, мөн шүдийг шүдээр хэмээн бичигдсэн байдаг;

39 Харин би та нарт хэлнэ, та нар хилэнцэттэй бүү “сөргөлд, харин баруун хацар дээр

24а су Уучлах.

26а Алма 11:3.

27а 2 Ниф. 9:36;
С ба Г 59:6.

28а С ба Г 42:23.
су Тачаадах.

29а Үйлс 8:22.

30а Мат. 10:38; 16:24;
Лук 9:23.

31а су Гэр бүл салалт.

32а Марк 10:11–12.

б су Садар самуун.
в су Завхайрал.

33а су Тангарга.

34а су Бүдүүлэг үг
хэллэг.

38а Лев. 24:20.

39а 3 Ниф. 6:13;

4 Ниф. 1:34;

С ба Г 98:23–32.

чинь хэн цохинов, ^бтүүнд нөгөө хацраа тавьж өг;

40 Мөн хэн нэгэн чамтай хуулиар заалдаж мөн хүрмийг тань авбал, түүнд орхимжоо ч түүнчлэн өг;

41 Мөн хэн нэгэн чамайг нэг бээр явахыг албадвал, түүнтэй хоёр бээр явагтун.

42 Чамаас гуйсанд “өг, мөн чамаас зээлэх гэсэн түүнд чи бүү араа харуул.

43 Мөн болгоогтун түүнчлэн, чи хөршөө хайрлаж мөн дайснаа үзэн яд гэж бичигдсэн байдаг;

44 Гэвч болгоогтун би та нарт хэлнэ, “дайснуудаа хайрла, чамайг зүхэх тэднийг адисал, чамайг үзэн ядах тэдэнд сайныг үйлд, мөн чамайг хүнлэг бусаар ашиглах мөн чамайг хавчин гадуурхах тэдний төлөө ^бзалбир;

45 Та нар тэнгэр дэх Эцэгийнхээ хүүхдүүд байж болохын тулд буюу; учир нь тэрбээр өөрийн нарыг хилэнцтийн дээр мөн сайны дээр мандах болгодог.

46 Тиймийн тул эрт цагийн тэдгээр зүйл, хуулийн харьяат байсан тэр нь, надаар бүгд гүйцэлдсэн билээ.

47 “Хуучин зүйлүүд төгсөж, мөн бүх зүйл шинэ боллоо.

48 Тиймийн тул би, эсвээс тэнгэрт буй Эцэг тань төгсийн адил та нарыг “төгс байгаасай хэмээнэ би.

БҮЛЭГ 13

Их Эзэний залбирлыг Есүс нифайчуудад заав—Тэд тэнгэрт эрдэнэс хураах ёстой—Арванхоёр тохинуулалдаа зуурдын зүйлүүдийн тухайд бодохгүй байхаар зарлиг болгогдов—Матай 6 дугаар бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мэ 34 он.

Үнэнээр, үнэнээр, би хэлнэ та нар ядууд “өглөг үйлдээсэй хэмээнэ би; харин тэдэнд харагдахын тулд хүмүүний өмнө өглөгөө үйлдэхгүй байхыг анхаар; эс бөгөөс тэнгэр дэх Эцэгээс тань та нарт шагнал үгүй бөлгөө.

2 Тиймийн тул тэд хүмүүнийг “алдар нэрийг олж болохын тулд, синагогт мөн гудамжинд хоёр нүүртнүүдийн үйлддэг шиг та нар өглөг үйлдэхдээ өөрсдийнхөө өмнө бүрээ бүү тат. Үнэнээр би та нарт хэлнэ, тэд шагналаа авсан билээ.

3 Харин чи өглөг үйлдэхдээ баруун гарынхаа юу хийж байгааг зүүн гартаа бүү мэдүүл;

4 Чиний өглөгүүд нууц байж болохын тулд буюу; мөн нууцыг хардаг Эцэг тань, өөрөө чамайг илээр шагнах болно.

5 Мөн чи “залбирахдаа хоёр нүүртнүүд шиг үйлдэж болохгүй, учир нь тэд хүмүүнд харагдаж болохын тулд тэд

39б су Тэвчээр.
42а Иаков 2:17–19;
Мозая 4:22–26.
44а Сур. үгс 24:17;
Алма 48:23.

б Үйлс 7:59–60.
47а 3 Ниф. 15:2, 7;
С ба Г 22:1.
48а Мат. 5:48;
3 Ниф. 27:27.

су Төгс.
13 1а су Өглөг, Өглөг
өгөх.
2а С ба Г 121:34–35.
5а су Залбирал.

синагогуудад мөн гудамжны буланд зогсон залбирах дуртай. Үнэнээр би та нарт хэлнэ, тэд шагналаа авсан билээ.

6 Харин чи, чи залбирахдаа, гонхондоо орж, мөн хаалгаа хаагаад, нууцад байх Эцэгтээ залбир; мөн нууцыг харах Эцэг тань, чамайг илээр шагнах болно.

7 Харин та нар залбирахдаа, буруу номтнууд шиг хоосон давталт бүү хэрэглэ, учир нь тэд ихийг яривал сонсогдох болно хэмээн боддог.

8 Та нар тиймийн тул тэдэнтэй адил бүү бай, учир нь та нарт юу хэрэгтэй байгааг түүнээс гуйхаас чинь өмнө Эцэг тань “мэддэг юм.

9 Тиймийн тул та нар энэ “маягаар” залбир: Тэнгэрт буй “Эцэг минь, нэр тань ариусан алдаршиг.

10 Таны таалал тэнгэрт гүйцэлддэг шигээ газар дээр ч тэгэх болтугай.

11 Мөн бид өртнүүдээ уучлахын хэрээр, бидний өрийг өршөөгөөч.

12 Мөн биднийг уруу таталтын зүг “бүү дагуулаач, харин биднийг хилэнцээс чөлөөлөөч.

13 Учир нь хаант улс, мөн хүч, мөн алдар суу, үүрд таных. Амен.

14 Учир нь, хэрэв та нар хүмүүнийг алдаануудынх нь учир “уучлах аваас тэнгэрлэг

Эцэг тань түүнчлэн та нарыг өршөөх болно;

15 Харин хэрэв та нар хүмүүнийг алдаануудынх нь төлөө уучлахгүй бол Эцэг тань ч та нарын алдаануудыг өршөөх нь үгүй.

16 Цаашилбал, та нар “мацаг барихдаа, хоёр нүүртнүүд шиг гунигтай төрх бүү гарга, учир нь тэд мацаг барьж буйгаа хүмүүнд харуулж болохын тулд царайгаа барайлгадаг. Үнэнээр би та нарт хэлнэ, тэд шагналаа авсан юм.

17 Харин чи, мацаг барихдаа, толгойдоо тос түрхэж, мөн нүүрээ угаа;

18 Чи мацаг барьж буйгаа хүмүүнд бус, харин нууцад байх Эцэгтээ харуулахын тулд болой; мөн “нууцыг харах Эцэг тань чамайг илээр шагнах болно.

19 Өөрсөддөө газар дэлхий дээр баялаг бүү хураа, тэнд цагаан эрвээхий мөн зэв идэж мөн хулгайч нар эвдэн ороод мөн хулгайлдаг;

20 Харин өөрсөддөө тэнгэрт “баялаг хураа, тэнд цагаан эрвээхий мөн зэв идэхгүй мөн хулгайч нар эвдэн орж бас хулгайлах нь үгүй.

21 Учир нь баялаг тань хаана байна, тэнд зүрх сэтгэл тань түүнчлэн байдаг.

22 Биеийн “гэрэл нь нүд ажгуу, тиймийн тул, хэрэв нүд

8а С ба Г 84:83.

9а Мат. 6:9–13.

б су Залбирал.

в су Бурхан, Бурхан тэргүүтэн —Эцэг Бурхан.

12а исо, Мат. 6:14.

14а Мозая 26:30–31;

С ба Г 64:9.

су Уучлах.

16а Иса. 58:5–7.

су Мацаг барих,

Мацаг барилт.

18а С ба Г 38:7.

20а Хил. 5:8; 8:25.

22а С ба Г 88:67.

чинь нэгэн чигт байх аваас, бүхэл бие чинь гэрлээр дүүрэн байх болно.

23 Харин нүд чинь хилэнцэт аваас бүхэл бие чинь харанхуйгаар дүүрэн байх болно. Тиймийн тул, хэрэв чамд байх гэрэл нь харанхуй аваас, тэрхүү харанхуй нь хичнээн агуу байх билээ!

24 Нэг ч хүн хоёр эзэнд зэрэг “үйлчилж чадахгүй; учир нь тэр нэгийг нь үзэн ядаж мөн нөгөөг нь хайрлах болно, эсвэл тэр нэгэнд нь үнэнч байж мөн нөгөөг нь зэвүүцэх болно. Та нар Бурханд бас Эд хөрөнгөнд зэрэг үйлчилж чадахгүй.

25 Мөн эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр үгийг яриад өөрийн сонгосон арванхоёрыг харж, мөн тэдэнд хэлэв: Миний ярьсан үгсийг сана. Учир нь болгоогтун, та нар энэ хүмүүст “тохинуулахаар миний сонгосон тэд билээ. Тиймийн тул би та нарт хэлнэ, “аминыхаа төлөө, та нар юу идэх, эсвээс юу уухав; бас биеийнхээ төлөө, юу өмсөхөв хэмээн санаа тавих хэрэггүй. Амь нь махнаас илүү, бие нь хувцаснаас илүү бус уу?

26 Агаар дахь жигүүртнүүдийг болгоогтун, учир нь тэд тариалдаггүй, бас хадаж бас хороонд хураадаггүй; гэсэн ч тэнгэрлэг Эцэг тань тэднийг тэжээдэг. Та нар тэдгээрээс хавьгүй илүү бус уу?

27 Та нарын хэн нь санаа тавьснаараа биеийнхээ өндрийг нэг тохой нэмэгдүүлж чадах билээ?

28 Мөн та нар юуны учир хувцас хунарын төлөө санаа тавих билээ? Талбай дахь сараана цэцгүүд хэрхэн ургадгийг бодож үз; тэд хөдөлмөрлөдөггүй, бас ээрдэг ч үгүй;

29 Мөн гэвч би та нарт хэлнэ, бүр Соломон алдрынхаа оргилд байхдаа ч, эдгээрийн нэгэнтэй нь ч адил хувцаслаж байгаагүй юм.

30 Иймийн тул, хэрэв Бурхан, өнөөдөр байгаа мөн маргааш нь зууханд хаягдах талын өвсийг ийн хувцасласан бол, үүнчлэн тэрбээр та нарыг хувцаслах болно, хэрэв та нар бага итгэлтэй бус аваас.

31 Тиймийн тул, Бид юу идэх билээ? эсвээс, Бид юу уух билээ? эсвээс, Бид юугаар хувцаслах билээ? хэмээн бүү санаа зов.

32 Учир нь тэнгэрлэг Эцэг тань та нарт эдгээр бүх зүйл хэрэгтэйг мэддэг.

33 Харин та нар эхлээд Бурханы “хаант улсыг мөн түүний зөв шударгыг эрэлхийл, мөн эдгээр бүх зүйл та нарт нэмэгдэн өгөгдөх болно.

34 Тиймийн тул маргаашийн төлөө санаа бүү тавь, учир нь маргааш нь өөрөө өөрийнхөө зүйлүүдэд санаа тавих болно. Тухайн өдрийн хилэнц нь тэр өдөртөө хангалттай билээ.

БҮЛЭГ 14

Есүс зарлигласан нь: Бүү шүүг-түн; Бурханаас гуйгтун; хуурамч бошиглогчдоос сэрэмжлэгтүн — Тэрбээр Эцэгийн тааллыг үйлдэх тэдэнд авралыг амлав — Матай 7 дугаар бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мэ 34 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр үгийг яриад цугласан олонд тэрээр дахин хандаж, мөн тэдний зүг дахин ам нээж, хэлсэн нь: Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, Бүү “шүүгтүн, та нар шүүгдэхгүйн тулд болой.

2 “Учир нь та нар ямар шүүлтээр шүүнэ, та нар түүгээрээ шүүгдэх болно; мөн та нар ямар хэмжээгээр хэмжинэ, та нар тэрчлэн хэмжигдэх болно.

3 Мөн чи яагаад ах дүүгийнхээ нүдэн дэх үртсийг болгоодог хэрнээ өөрийнхөө нүдэн дэх дүнзийг анзаардаггүй билээ?

4 Эс бөгөөс чи ах дүүдээ: Нүдэн дэх үртсийг чинь аваад өгье хэмээн — мөн болгоогтун, өөрийн тань нүдэнд дүнз байхад хэрхэн хэлэх билээ?

5 Хоёр нүүртэн чи, эхлээд өөрийнхөө нүднээс “дүнзийг гаргаж хая; мөн тэгээд чи ах дүүгийнхээ нүднээс үртсийг авч хаяхаа сайн харах болно.

6 “Ариун болох түүнийг нох-

дод бүү өг, бас гахайн өмнө сувдаа бүү хая, тэд тэдгээрийг хөл дороо дэвслээд, мөн эргэж бас чамайг ураг болуузай.

7 “Гуй, тэгвэл энэ нь та нарт өгөгдөх болно; эрэлхийл, тэгвэл та нар олох болно; тогш тэгвэл энэ нь та нарт нээгдэх болно.

8 Учир нь гуйсан болгон хүлээн авдаг; мөн эрэлхийлэх тэр нь, олдог; мөн тогшсон түүнд энэ нь нээгдэх болно.

9 Эсвэл та нарын хэн нь, хүүгээ талх гуйхад, түүнд чулуу өгөх билээ?

10 Эсвэл түүнийг загас гуйхад, тэр түүнд могой өгөх бил үү?

11 Хэрэв тэгээд та нар, хилэнцэт байж, хүүхдүүддээ хэрхэн сайн бэлэг өгөхийг мэддэг бол, тэнгэр дэх Эцэг тань түүнээс гуйсан тэдэнд сайн зүйлийг хичнээн ихээр өгөх билээ?

12 Тиймийн тул, хүмүүн өөрсдөд тань хэрхэн хандахыг хүсдэгчлэн юуг боловч, бүх зүйлийг, та нар тэдэнд түүнчлэн “үйлд, учир нь энэ бол хууль хийгээд бошиглогчид билээ.

13 Та нар “давчуу хаалгаар орогтун; учир нь устгалд хөтлөх тэр зам “уужим, мөн хаалга нь өргөн, мөн түүгээр ордог нь олон байдаг.

14 Учир юун гэвэл амьдралд удирдах тэр “хаалга давчуу,

14 1а iso, Mat. 7:1–2;
Иохан 7:24.
2а Морм. 8:19.
5а Иохан 8:3–11.
6а су Ариун.

7а 3 Ниф. 27:29.
су Залбирал.
12а су Өрөвч сэтгэл.
13а Лук 13:24;
3 Ниф. 27:33.

б С ба Г 132:25.
14а 2 Ниф. 9:41; 31:9,
17–18; С ба Г 22:1–4.

мөн зам нь ^бнарийн, мөн үүнийг олдог нь ^вцөөхөн байдаг.

15 Хонины арьс нөмрөн та нарт ирэх, “хуурамч бошиглогчдоос сэрэмжил, харин дотор нь улангассан чононууд байдаг.

16 Та нар тэднийг үр жимсээр нь таних болно. Хүмүүн өргөнөөс усан үзэм, эсвээс халгайнаас инжир хураадаг гэж үү?

17 Үүнчлэн сайн мод болгон сайн жимс өгдөг; харин ялзарсан мод хилэнцэт үр жимс өгдөг.

18 Сайн мод хилэнцэт үр жимс өгч, бас ялзарсан мод ч сайн үр жимс өгч чадахгүй.

19 Сайн үр жимс “өгдөггүй мод болгон тас цавчигдаж, мөн галд хаягддаг.

20 Иймийн тул, “үр жимсээр нь та нар тэднийг таних болно.

21 Их Эзэн минь, Их Эзэн минь гэж надад хэлдэг болгон тэнгэрийн хаант улсад орохгүй; харин тэнгэр дэх Эцэгийн минь тааллыг биелүүлдэг тэр нь бөлгөө.

22 Олон нь тэр өдөр надад “хэлэх болно: Их Эзэн, Их Эзэн, бид таны нэрээр бошиглож мөн таны нэрээр чөтгөрүүдийг зайлуулж, мөн таны нэрээр олон гайхамшигт ажлыг үйлдээгүй гэж үү?

23 Мөн тэгэхэд би тэдэнд

өгүүлнэ: Би та нарыг огт “танихгүй; алдсыг үйлдэгч та нар надаас ^бхолд.

24 Тиймийн тул, эдгээр үгсийг минь сонсоод, тэдгээрийг биелүүлэх хэнийг боловч, түүнийг “хадан дээр байшингаа барьсан мэргэн хүнтэй би адилтгах болно—

25 Мөн “бороо орж, бас үер бууж, тэгээд салхи үлээж, мөнхүү байшинг нүдэв; мөн энэ нь ^вунасангүй, учир нь хадан дээр суурилсан байв.

26 Мөн эдгээр үгийг минь сонсоод, мөн тэдгээрийг үл биелүүлдэг болгон, “элсэн дээр байшингаа барьсан мунхаг хүнтэй адилтгагдах болно—

27 Мөн бороо орж, бас үер бууж, тэгээд салхи үлээж, мөнхүү байшинг нүдэв; мөн энэ нь унасан байв, мөн уналт нь агуу байлаа.

БҮЛЭГ 15

Мосегийн хууль түүгээр гүйцэлдсэнийг Есүс зарлав—Иерусалимд түүний ярьсан өөр хонинууд бол нифайчууд юм—Алдсын учир, Иерусалим дахь Их Эзэний хүмүүс Израилын тараагдсан хонины тухай мэддэггүй байв. Ойролцоогоор мэ 34 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр үгээ төгсгөөд

14б 1 Ниф. 8:20.

в 1 Ниф. 14:12.

15а Иер. 23:21–32;

2 Ниф. 28:9, 12, 15.

19а Мат. 3:10;

Алма 5:36–41;

С ба Г 97:7.

20а Лук 6:43–45;

Моро. 7:5.

22а Алма 5:17.

23а Мозая 5:13; 26:24–27.

б Лук 13:27.

24а су Хад.

25а Алма 26:6;

Хил. 5:12.

б Сур. үгс 12:7.

26а 3 Ниф. 11:40.

тэрбээр цугласан олны зүг хараа бэлчээн, мөн тэдэнд хэлэв: Болгоогтун, намайг Эцэгтээ дээш одохоос өмнө миний заасан зүйлүүдийг та нар сонслоо; тиймийн тул, миний эдгээр үгийг санаж мөн эдгээрийг “биелүүлэх хэнийг боловч, түүнийг би эцсийн өдөр ^бөргөмжлөх болно.

2 Мөнхүү улиран тохиох дор Есүс эдгээр үгийг хэлээд “Мосегийн хуулийн талаар өөрийг нь юу хүсч буй бол хэмээн гайхширч мөн гайхсан зарим нь тэдний дунд буйг ухаарав; учир нь хуучин зүйлүүд улирч одоод, мөн бүх зүйл шинэ болсон гэснийг тэд ойлгосонгүй.

3 Мөн тэрбээр тэдэнд хэлэв: Хуучин зүйлүүд улирч одоод, мөн бүх зүйл шинэ болсон гэж би та нарт хэлсэнд бүү гайх.

4 Болгоогтун, Мосед өгөгдсөн “хууль гүйцэлдсэнийг би та нарт хэлнэ.

5 Болгоогтун, “би бол хуулийг өгсөн тэр билээ, мөн би бол Израил дахь өөрийн хүмүүстэй гэрээ хийсэн тэр билээ; тиймийн тул, хууль нь надаар гүйцэлдсэн, учир нь би уг хуулийг ^бгүйцэлдүүлэхээр ирсэн; тиймийн тул энэ нь төгсгөл болов.

6 Болгоогтун, би бошиглогч-

дыг “устгадаггүй, учир нь надаар гүйцэлдээгүй болгон нь, үнэнээр би та нарт хэлнэ, бүгд гүйцэлдэх болно.

7 Мөн би та нарт хуучин зүйлүүд улирч одсон хэмээн хэлсэн учраас, ирэх тэр зүйлүүдийн талаар яригдсан тэрнийг би устгахгүй.

8 Учир нь болгоогтун, өөрийн хүмүүстэй хийсэн миний “гэрээ бүгд гүйцэлдээгүй; гэвч Мосед өгөгдсөн хууль надаар төгсгөл болсон бөлгөө.

9 Болгоогтун, би бол “хууль, мөн ^бгэрэл. Надад хандагтун, мөн эцсээ хүртэл тэвчигтүн, мөн та нар амьдрах болно; учир нь эцсээ хүртэл “тэвчсэн түүнд би мөнх ‘амьдрал өгөх болно.

10 Болгоогтун, би та нарт “зарлигууд өгсөн билээ; тиймийн тул зарлигуудыг минь дага. Мөн энэ бол хууль хийгээд бошиглогчид, учир нь тэд үнэхээр миний тухай ^бгэрчилсэн юм.

11 Мөн эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр үгийг яриад, тэрбээр өөрийн сонгосон арванхоёрт хэлэв:

12 Та нар миний шавь нар; мөн та нар “Иосефын угсааны үлдэгдэл болох энэ хүмүүст гэрэл билээ.

13 Мөн болгоогтун, энэ бол

15 1а Иаков 1:22.

б 1 Ниф. 13:37;

С ба Г 5:35.

2а су Мосегийн хууль.

4а Мозая 13:27–31;

3 Ниф. 9:17–20.

5а 1 Кор. 10:1–4;

3 Ниф. 11:14.

су Иехова.

б Алма 34:13.

6а 3 Ниф. 23:1–5.

8а 3 Ниф. 5:24–26.

9а 2 Ниф. 26:1.

б су Гэрэл, Христийн гэрэл.

в су Тэвчих.

г Иохан 11:25;

С ба Г 84:44.

10а 3 Ниф. 12:20.

б Мозая 13:33.

12а су Иосеф, Иаковын хүү.

та нарын өвлөсөн “нутаг; мөн Эцэг үүнийг та нарт өгсөн бөлгөө.

14 Иерусалим дахь ах дүүст тань үүнийг “хэл хэмээх зарлигийг Эцэг надад хэзээ ч өгч байгаагүй.

15 Басхүү Эцэг нутгаас нь гарган удирдсан, Израилын угсааны “бусад овгуудын талаар намайг тэдэнд хэл хэмээх зарлигийг Эцэг хэзээ ч надад өгч байгаагүй.

16 Эцэгийн надад зарлигласнаар, өдий зэргийг би тэдэнд хэлэх ёстой:

17 Энэ хорооных бус өөр хонинууд надад бий; би тэднийг түүнчлэн авчрах ёстой, мөн тэд дуу хоолойг минь сонсох болно; мөн нэг хороо, мөн нэг “хоньчин байх болно.

18 Мөн эдүгээ, гэжүүд мөн итгэлгүйн учир миний үгийг тэд “ойлгосонгүй; тиймийн тул энэ зүйлийн талаар тэдэнд илүүг ярихгүй байхыг би Эцэгээр зарлиг болгогдсон билээ.

19 Гэвч, үнэнээр, би та нарт хэлнэ, Эцэг надад зарлиг болгож, мөн би үүнийг та нарт хэлнэ, та нар тэдний дундаас алдсуудынх нь учир тусгаарлагдсан; тиймийн тул тэд та нарын тухай мэддэггүй нь тэдний алдсын учир билээ.

20 Мөн бусад овгуудыг Эцэг тэднээс тусгаарласныг үнэнээр би та нарт тэрчлэн хэлье; мөн тэдний тухай тэд мэддэггүй нь өөрсдийнх нь алдсын улмаас болой.

21 Мөн үнэнээр би та нарт хэлнэ, та нар бол миний тухайлан хэлсэн тэд билээ: энэ хорооных бус “өөр хонинууд надад бий; би тэднийг түүнчлэн авчрах ёстой, мөн тэд дуу хоолойг минь сонсох болно; мөн нэг хороо, мөн нэг хоньчин байх болно.

22 Мөн тэд намайг ойлгосонгүй, учир нь энэ бол “харийнхан хэмээн тэд бодсон аж; учир нь харийнхан өөрсдийнх нь номлолоор дамжин ^бхөрвүүлэгдэх болно гэдгийг тэд ойлгоогүй ажээ.

23 Мөн тэд дуу хоолойг минь сонсох болно гэж би хэлснийг тэд ойлгоогүй байв; мөн “харийнхан хэзээ ч миний дуу хоолойг сонсохгүй гэхэд тэд намайг ойлгосонгүй—^бАриун Сүнсээр бус аваас би өөрийгөө тэдэнд үзүүлэхгүй гэдгийг болой.

24 Гэвч болгоогтун, та нар аль аль нь “миний дуу хоолойг сонссон, мөн намайг харсан; мөн та нар миний хоньд, мөн та нар надад Эцэгийн ^бөгсөн тэдний дунд тоологддог билээ.

13a 1 Ниф. 18:22–23.

14a 3 Ниф. 5:20.

15a 3 Ниф. 16:1–4.

су Израил—
Израилын
алдагдсан арван
овог.

17a су Сайн Хоньчин.

18a С ба Г 10:59.

21a Иохан 10:14–16.

22a су Харийнхан.

б Үйлс 10:34–48.

23a Мат. 15:24.

б 1 Ниф. 10:11.

су Ариун Сүнс.

24a Алма 5:38;

3 Ниф. 16:1–5.

б Иохан 6:37;

С ба Г 27:14.

БҮЛЭГ 16

Есүс Израилын төөрөлдсөн хонинуудын бусад заримд нь зочлох болно — Хожмын өдрүүдэд сайн мэдээ харийнханд мөн дараа нь Израилын угсаанд очих болно — Их Эзэний хүмүүс Сионыг тэрээр дахин авчрахыг нүдээрээ үзэх болно. Ойролцоогоор мэ 34 он.

Мөн үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ энэ нутагт бас Иерусалимын нутагт ч, бас миний тохинуулсан тэндхийн эргэн тойрны нутгийн аль ч хэсэгт байхгүй “өөр хонинууд надад бий.

2 Учир нь миний тухайлан ярьж байгаа тэд дуу хоолойг минь хараахан сонсоогүй тэд билээ; бас би тэдэнд өөрийгөө огт үзүүлээгүй байгаа.

3 Гэвч нэг хороо байж мөн нэг хоньчинтой байж болохын тулд намайг “тэдэнд очиж, мөн тэд дуу хоолойг минь сонсож, мөн хонинуудын минь дунд тоологдох болно гэсэн зарлигийг би Эцэгээс хүлээн авсан; тиймийн тул өөрийгөө тэдэнд үзүүлэхээр би явна.

4 Мөн хэрэв намайг харсан мөн надтай хамт тохинуулалд минь байсан Иерусалим дахь миний хүмүүс та нарын тухай, мөн түүнчлэн тэд тухайлан мэдэхгүй бусад

овгуудын тухай мэдлэгийг Ариун Сүнсээр хүлээн авч болохын тулд миний нэрээр Эцэгээс асуухгүй аваас, итгэлгүйнхээ учир газрын гадаргуу дээр тараагдах тэдний үр удмын үлдэгдэл нь, харийнханы бүрэн байдлаар дамжуулан, дотогш авчрагдаж болно, өөрөөр хэлбэл тэдний Гэтэлгэгч болох миний тухай “мэдлэгт авчрагдаж болохын тулд та нарын бичих эдгээр үгс “харийнханд хадгалагдаж мөн үзүүлэгдэхийн тулд намайг явсны дараа эдгээр үгийг та нар “бичихийг би та нарт зарлиг болгож байна.

5 Мөн тэгээд би тэднийг газар дэлхийн дөрвөн зүгээс “цуглуулах болно; мөн тэгээд Израилын “угсааны бүх хүмүүстэй Эцэгийн хийсэн “гэрээг би гүйцэлдүүлэх болно.

6 Мөн “харийнхан адислагдсан болой, учир юун гэвэл миний тухай мөн Эцэгийн тухай тэдэнд гэрчлэх “Ариун Сүнсээр ирдэг надад итгэх тэрхүү итгэлийнх нь учир билээ.

7 Болгоогтун, надад итгэх тэдний итгэлийн учир, мөн та нарын итгэлгүйн учир, Ай Израилын угсаа, “хожмын өдөр эдгээр зүйлийн бүрэн байдал тэдэнд мэдүүлэгдэхийн тулд харийнханд үнэн

16 1a 3 Ниф. 15:15.
су Израил—
Израилын
алдагдсан арван
овог.

3a 3 Ниф. 17:4.

4a Езек. 20:42–44;

3 Ниф. 20:13.

б 1 Ниф. 10:14;

3 Ниф. 21:6.

в су Судрууд.

5a су Израил—

Израилын

цугларалт.

б 1 Ниф. 22:9;

3 Ниф. 21:26–29.

в 3 Ниф. 5:24–26.

6a 1 Ниф. 13:30–42;

2 Ниф. 30:3.

б 2 Ниф. 32:5;

3 Ниф. 11:32, 35–36.

су Ариун Сүнс.

7a су Сайн Мэдээний
сэргээлт.

ирэх болно хэмээн Эцэг хэлдэг.

8 Гэвч Эцэг хэлдэг, харийнханы итгэлгүй тэдэнд халаг — учир нь тэд энэ нутгийн гадаргуу дээр ирсэн мөн Израилын угсааных болох миний хүмүүсийг “тараасан; мөн Израилын угсааных болох миний хүмүүс тэдний дундаас ^бзайлуулагдсан, мөн тэдний хөл дор тэднээр дэвслэгдсэн бөлгөө;

9 Мөн харийнханд хандах Эцэгийн нигүүлслийн, мөн түүнчлэн Израилын угсааных болох миний хүмүүсийн дээрх Эцэгийн шүүлтүүдийн учир, үнэнээр үнэнээр, би та нарт хэлнэ, энэ бүгдийн дараа, мөн Израилын угсааных болох өөрийн хүмүүсийг би цохигдож, мөн зовоогдон, мөн “хөнөөгдөх, мөн тэдний дундаас зайлуулагдан, мөн тэднээр үзэн ядагдаж, мөн тэдний дунд муу хэлэгдэх болгосон мөн муугийн зүйр болгосон билээ —

10 Мөн Эцэг тийн зарлигласан, намайг та нарт ийн хэлэхийг: Харийнхан миний сайн мэдээний эсрэг нүгэл үйлдэж, мөн миний сайн мэдээний бүрэн байдлыг эсэргүүцэн, мөн бүх үндэстнүүдийн дээгүүр, мөн бүх газар дэлхийн бүх хүмүүсийн дээгүүр, зүрх сэтгэлийнхээ бардамналд “хөөрч, мөн бүх төрлийн худал

хэлж, мөн хуурч, мөн түүнчлэн бүх төрлийн хоёр нүүр гарган, мөн аллагууд, мөн ^бсанваараар мэргэших явдал, мөн садар самуун, мөн нууц жигшүүрт хэргүүдээр дүүрэх тэр өдөр; мөн хэрэв тэд эдгээр бүх зүйлийг хийж, мөн миний сайн мэдээний бүрэн байдлыг эсэргүүцвэл, болгоогтун, би сайн мэдээнийнхээ бүрэн байдлыг тэдний дундаас авах болно хэмээн Эцэг хэллээ.

11 Мөн тэгээд би өөрийн хүмүүстэй хийсэн гэрээгээ “санах болно, Ай Израилын угсаа, мөн би тэдэнд сайн мэдээгээ авчрах болно.

12 Мөн, Ай Израилын угсаа, харийнхан чамайг давамгайлах хүчгүй гэдгийг би чамд үзүүлэх болно; харин би чамтай хийсэн гэрээгээ санах болно, Ай Израилын угсаа, мөн та нар миний сайн мэдээний бүрэн байдлын “мэдлэгт ирэх болно.

13 Гэвч хэрэв харийнхан наманчилж мөн надад эргэж ирэх аваас, болгоогтун тэд миний хүмүүсийн, Ай Израилын угсааны дунд “тоологдох болно хэмээн Эцэг хэлдэг.

14 Мөн Израилын угсаа болох өөрийн хүмүүсийг тэдний дундуур явж, мөн доош дэвслэхийг би зөвшөөрөхгүй хэмээн Эцэг хэлдэг.

15 Гэвч хэрэв тэд надад

8а 1 Ниф. 13:14;
Морм. 5:9, 15.
б 3 Ниф. 20:27–29.
9а Амос 9:1–4.
10а Морм. 8:35–41.

б 2 Ниф. 26:29.
11а 3 Ниф. 21:1–11;
Морм. 5:20.
12а Хил. 15:12–13.
13а Гал. 3:7, 29;

1 Ниф. 15:13–17;
2 Ниф. 10:18;
3 Ниф. 30:2;
Абр. 2:9–11.

хандахгүй, мөн дуу хоолойг минь анхааран сонсохгүй аваас, тэдний дундуур явахыг, мөн тэднийг доош “дэвслэхийг би тэдэнд зөвшөөрөх болно, тийм ээ, би өөрийн хүмүүст, Ай Израилын угсаанд зөвшөөрөх болно, мөн тэд зайлуулагдаж, мөн Ай Израилын угсаа болох хүмүүсийн минь хөлд дэвслэгдэхээс өөр юунд ч хэрэггүй болох, амтаа алдсан давс лугаа адил байх болно.

16 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ—би энэ хүмүүст тэдний өв болгон энэ нутгийг өгөхийг Эцэг надад тийн зарлигласан билээ.

17 Мөн тэгээд бошиглогч Исаиагийн “үгс гүйцэлдэх болно, үүнд:

18 “Таны ^бхаруулууд дуу хоолойгоо өргөх болно; тэд дуу хоолойгоор хамтдаа дуулна; учир нь Их Эзэн Сионыг дахин авчрахыг тэд нүдээр үзэх болно.

19 Иерусалимын зэлүүд газрууд та нар баясан мөн хамтдаа дуулцгаа; учир нь Их Эзэн өөрийн хүмүүсийг тайтгаруулж, тэрээр Иерусалимыг гэтэлгэсэн болой.

20 Их Эзэн ариун мутраа бүх үндэстний нүдэнд харуулсан бөлгөө; мөн дэлхийн бүх хязгаарууд Бурханы авралыг үзэх болно.

БҮЛЭГ 17

Түүний үгийг тунгааж мөн ойлголтын төлөө залбирахыг Есүс хүмүүст зааварлав—Тэрбээр тэдний өвчтэйг нь эдгээв—Тэрбээр бичигдэх аргагүй хэлийг хэрэглэн хүмүүсийн төлөө залбирав—Тэдний багачуудыг нь гал хүрээлж мөн тэнгэр элчүүд тохинуулав. Ойролцоогоор мэ 34 он.

Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр үгсийг яриад тэрбээр цугласан олныг нүд гүйлгэн харав, мөн тэрбээр тэдэнд хэлэв: Болгоогтун, “цаг минь ирлээ.

2 Та нар сул дорой, иймээс энэ үед та нарт ярихаар Эцгээр надад зарлиг болгогдсон бүх үгсийг минь та нар “ойлгож чадахгүйг би ухамсарлаж байна.

3 Тиймийн тул, та нар гэр гэртээ харьцгаа, мөн миний хэлсэн зүйлсийг “эргэцүүлж, мөн, та нар ойлгож, мөн би та нарт дахин ирэх ^бмаргаашийн төлөө оюун санаагаа “бэлтгэж болохын тулд миний нэрээр Эцэгээс асуу.

4 Гэвч эдүгээ би Эцэгт “очиж, мөн түүнчлэн Израилын ^бтөөрөлдсөн овгуудад өөрийгөө “үзүүлэхээр явлаа, учир нь Эцэгийн хувьд тэд төөрөлдөөгүй, учир нь тэрбээр

15а Мика 5:8–15;
3 Ниф. 20:16–19;
21:12–21; С ба Г 87:5.
17а 3 Ниф. 20:11–12.
18а Иса. 52:8–10.
б Езек. 33:1–7.
су Харах, Харуул.

17 1а ө.х. Эцэгт буцаж очих. Шүлэг 4-ийг үз.
2а Иохан 16:12;
С ба Г 78:17–18.
3а су Тунгаан бодох.
б 3 Ниф. 19:2.

в С ба Г 132:3.
4а 3 Ниф. 18:39.
б су Израил—
Израилын алдагдсан арван овог.
в 3 Ниф. 16:1–3.

тэднийг хааш аваачсаныгаа өөрөө мэддэг.

5 Мөнхүү улиран тохиох дор Есүс ийн яриад, тэрбээр дахин цугларсан олны зүг хараа бэлчээж, мөн тэд нулимс унагаж буйг, мөн тэд өөрийг нь тэдэнтэй хамт дахин хэсэгхэн зуур ч гэсэн үлдэхийг гуйх мэт түүний зүг тэд ширтэн харж байхыг болгоов.

6 Мөн тэрбээр тэдэнд хэлэв: Болгоогтун, та нарт хандсан “өрөвдөх сэтгэлээр зүрх сэтгэл минь дүүрэв.

7 Та нарын дунд өвчтөнүүд байна уу? Тэднийг нааш авчрагтун. Доголон, эсвээс хараагүй, эсвээс хазгар, эсвээс тахир дутуу, эсвээс уяман өвчтэй, эсвээс татанги, эсвээс дүлий, эсвээс ямар нэгэн байдалд зовж зүдэрсэн нэгэн байна уу? Тэднийг нааш авчрагтун мөн би тэднийг эдгээх болно, учир нь та нарыг өрөвдөх сэтгэл надад буй; зүрх сэтгэл минь нигүүлслээр дүүрэв.

8 Учир нь Иерусалим дахь ах дүүст тань миний юу хийснийг өөрсдөд тань үзүүлээсэй хэмээх та нарын хүслийг би ухамсарлаж байна, учир нь та нарыг эдгээхэд “итгэл тань ^бхангалттайг би харж байна.

9 Мөнхүү улиран тохиох дор түүнийг тийн ярихад, бүх цугласан олон, нэгэн зэрэг, өвчтэй мөн зовж зүдэрсэн,

мөн доголон, мөн хараагүй, мөн хэлгүй, мөн ямар нэгэн байдлаар зовж зүдэрсэн тэд бүгдтэйгээ урагшлав; мөн тэрбээр тэднийг түүнд авчрагдахад нэг бүрчлэн “эдгээв.

10 Мөн тэд бүгд, эдгээгдсэн тэд мөн эрүүл байсан тэд аль аль нь, түүний хөлд доош бөхийн мөн түүнийг бишрэв; мөн цугласан нь олон байсан хэдий ч, ирж чадсан болгон нь түүний хөлийг “үнсэж, үүний хэрээр түүний хөлийг тэд нулимсаараа булхав.

11 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр тэдний “бяцхан хүүхдүүд авчрагдахыг зарлиг болгов.

12 Иймээс тэд бяцхан хүүхдүүдээ авчирч мөн тэднийг түүний эргэн тойронд газарт доош тавив, мөн Есүс голд нь зогсов; мөн цугласан олон тэднийг түүнд бүгдийг нь авчрах хүртэл зай тавьж өгөв.

13 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгд авчрагдаж, мөн Есүс голд нь зогсоод, тэрбээр цугласан олонд тэд доош газарт “сөхрөхийг зарлиг болов.

14 Мөнхүү улиран тохиох дор тэднийг газарт сөхөрцгөөхөд, Есүс дотроо санаа алдан, мөн хэлэв: Эцэг минь, Израилын угсааны хүмүүсийн ёс бусын учир би “шаналнам.

15 Мөн тэрээр эдгээр үгийг хэлээд, тэр өөрөө түүнчлэн газар дээр сөхрөв; мөн болгоогтун тэр Эцэгт хандан

6а су Өрөвч сэтгэл.
8а Лук 18:42.
б 2 Ниф. 27:23;
Ифр 12:12.

9а Мозая 3:5;
3 Ниф. 26:15.
10а Лук 7:38.
11а Мат. 19:13–14;

3 Ниф. 26:14, 16.
13а Лук 22:41;
Үйлс 20:36.
14а Моисе 7:41.

залбирав, мөн түүний залбирсан зүйлүүд бичигдэх аргагүй байлаа, мөн түүнийг сонссон олон түмэн гэрчилсэн билээ.

16 Мөнхүү ийм маягаар тэд гэрчилдэг: Эцэгт хандан Есүсийн ярьсныг бид харж мөн сонссон шиг тийм агуу хийгээд гайхамшигт зүйлүүд урьд нь “нүдэнд хэзээ ч үзэгдээгүй, бас чихэнд хэзээ ч сонсогдоогүй бөлгөө;

17 Мөн Есүсийн ярьсныг бидний харж бас сонссон шиг тийм агуу хийгээд гайхамшигт зүйлсийг “хэлээр хэлэх аргагүй, бас ямар ч хүмүүнээр бичигдэх аргагүй, бас хүмүүн зүрх сэтгэлдээ төсөөлөхийн аргагүй; мөн бидний төлөө Эцэгт хандан түүний залбирсныг бид сонссон тэр цагт бодгалийг маань дүүргэсэн тэрхүү баяслыг хэн ч төсөөлж чадахгүй буйза.

18 Мөнхүү улиран тохиох дор Эцэгт хандсан залбирлаа Есүс дуусгаад, тэр босов; харин олон түмний “баясал ийм агуу их байснаас тэд халгилан тэнхээ алдрав.

19 Мөнхүү улиран тохиох дор Есүс тэдэнд ярьж, мөн босохыг тэдэнд тушаав.

20 Мөн тэд газраас босч, мөн тэрээр тэдэнд хэлсэн нь: Итгэлийнхээ учир адислагдсан болой та нар. Мөн эдүгээ болгоогтун, миний баясал дүүрэн байна.

21 Мөн тэрээр эдгээр үгсийг хэлээд, “уйлж, мөн олон

түмэн үүнийг гэрчлэв, мөн тэрээр тэдний бяцхан хүүхдүүдийг нэг нэгээр нь авч, мөн тэднийг “адислав, мөн тэдний төлөө Эцэгт хандан залбирав.

22 Мөн тэр үүнийг хийгээд тэрээр дахин уйлав;

23 Мөн тэр олон түмэнд хандан ярьж, мөн тэдэнд: Бяцхан үрсээ болгоогтун хэмээн хэлэв.

24 Мөн тэд болгоохоор харахдаа харцаа тэнгэрийн зүг хандуулж, мөн тэд тэнгэр нээгдэхийг тэд үзэв, мөн тэд тэнгэр элчүүд тэнгэрээс галын дунд байгаа мэт доошлон ирэхийг үзэв; мөн тэд доош ирж мөн багачуудыг эргэн тойрон “хүрээлж, мөн тэд галаар эргэн тойрондоо хүрээлэгдсэн байв; мөн тэнгэр элчүүд тэдэнд тохинуулав.

25 Мөн цугласан олон үзэж мөн сонсож мөн гэрчлэв; мөн тэд өөрсдийнх нь цэдэг үнэнийг мэддэг, учир нь тэд бүгд өөрийн биеэр үзэж мөн сонссон болой; мөн тэд тоогоороо хоёр мянга таван зуу орчим бодгаль байв; мөн тэд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, мөн хүүхдүүдээс бүрдэж байв.

БҮЛЭГ 18

Нифайчуудын дунд Есүс ариун ёслолыг эхлүүлэв—Тэд түүний нэрээр үргэлж залбирахаар зар-

16а Иса. 64:4; 1 Кор. 2:9;
С ба Г 76:10,
114–119.

17а 2 Кор. 12:4.
18а су Баяр баясгалан.
21а Иохан 11:35.

б Марк 10:14–16.
24а Хил. 5:23–24, 43–45.

лиг болгогдов—Зохистой бусаар түүний маханбодийг идэх мөн түүний цусыг уух тэд яллагдаг—Ариун Сүнсийг өгөх хүч шавь нарт нь олгогдов. Ойролцоогоор мэ 34 он.

Мөнхүү улиран тохиох дор өөртөө хэсэг “талх мөн дарс авчрахыг Есүс шавь нартаа зарлиг болгов.

2 Мөн тэднийг талх мөн дарсанд явсан хойгуур, тэд газар дээр доош сууцгаахыг тэрбээр цугласан олонд зарлиглав.

3 Мөн шавь нар нь “талх мөн дарстай ирэхэд, тэрбээр талхнаас авч мөн хуваагаад мөн үүнийгээ адислав; мөн тэрбээр шавь нартаа өгч мөн тэдэнд идэхийг зарлиг болгов.

4 Мөн тэд идэж мөн ханахад, тэрбээр тэдэнд цугласан олонд өгөхийг зарлиглав.

5 Мөн цугласан олон идээд мөн ханахад, тэрбээр шавь нартаа хэлэв: Болгоогтун та нарын дундаас томилогдох нэг нь байх болно, мөн би түүнд хүчийг өгснөөр тэрбээр талхыг “хувааж мөн үүнийгээ адислан мөн миний сүмийн хүмүүст, итгэж мөн миний нэрээр баптисм хүртэх тэд бүгдэд үүнийг өгөх болно.

6 Мөн үүнийг та нар хийхээр, бүр яг миний хийсэн шигээр, би талхыг хувааж мөн үүнийг адисалж мөн үүнийг та нарт өгсний адилаар үргэлж чармайх болно.

7 Мөн та нар үүнийг та нарт миний үзүүлснээр миний бие махбодийг “төлөөлөн дурсаж үйлдэх болно. Мөн энэ нь Эцэгт та нар намайг үргэлж дурсан санаж байгаагийн гэрчлэл байх болно. Мөн хэрэв та нар намайг үргэлж санах аваас, миний Сүнс та нартай хамт байх болно.

8 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр эдгээр үгийг хэлээд, тэд аяган дахь дарснаас авч мөн үүнээс уухыг, мөн түүнчлэн тэд ууж болохын тулд цугласан олонд өгөхийг тэр шавь нартаа зарлиг болгов.

9 Мөнхүү улиран тохиох дор тэд үүнчлэн үйлдэж, мөн үүнээс ууж мөн ханав; мөн тэд цугласан олонд өгч, мөн тэд ууж, мөн тэд ханацгаав.

10 Мөн шавь нар нь үүнийг үйлдэхэд, Есүс тэдэнд хэлэв: Үйлдсэн энэ зүйлийнхээ төлөө адислагдсан болой та нар, учир нь энэ нь миний зарлигуудыг гүйцэлдүүлж, мөн та нар, өөрсдөдөө миний зарлигласныг үйлдэхэд бэлэн буйг энэ нь Эцэгт гэрчилдэг билээ.

11 Мөн наманчилж мөн миний нэрээр баптисм хүртсэн тэдэнд та нар үүнийг үргэлж үйлдэх болно; мөн та нарын төлөө асгаруулсан миний цусыг төлөөлөн дурсаж, та нар үргэлж намайг санаж байгаагаа Эцэгт гэрчилж болохын тулд та нар үүнийг үйлдэх болно. Мөн хэрэв та нар намайг үргэлж санах юм бол

миний Сүнс та нартай хамт байх болно.

12 Мөн эдгээр зүйлийг та нар үйлдэх болно хэмээх зарлигийг би та нарт өгч байна. Мөн хэрэв та нар эдгээр зүйлийг үргэлж үйлдэх аваас адислагдах болой та нар, учир нь та нар миний “хадан дээр барьж босгогдсон билээ.

13 Гэвч та нарын дундаас үүнээс илүүг эсвээс дутууг үйлдэх хэн боловч тэд миний хадан дээр барьж босгоогүй, харин элсэрхэг суурин дээр барьж босгосон ажгуу; мөн бороо цутгаж, бас үер бууж, тэгээд салхи үлээж, мөн тэднийг цохиход, тэд “унах болно, мөн тамын ^б үүд тэднийг хүлээн авахаар бэлэн нээлтэй байна.

14 Тиймийн тул намайг та нарт өгөхийг Эцэг надад зарлигласан тэрхүү зарлигуудыг минь хэрэв та нар дагах аваас адислагдсан болой та нар.

15 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, та нар чөтгөрөөр уруу татагдаж, мөн та нар түүгээр боолчлогдон удирдагдах болуузай хэмээн та нар үргэлж сэрэмжилж мөн “залбирах ёстой.

16 Мөн наманчилдаг мөн миний нэрээр баптисм хүртдэг миний хүмүүсийн дунд, би та нарын дунд залбирсан шиг, та нар түүнчлэн миний

сүмд залбирах болно. Болгоогтун би бол “гэрэл; би та нарт ^бүлгэр жишээ үзүүлсэн билээ.

17 Мөнхүү улиран тохиох дор Есүс эдгээр үгийг шавь нартаа яриад, тэрбээр дахин цугласан олонд хандаж мөн тэдэнд хэлэв:

18 Болгоогтун, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, та нар уруу таталтанд орохгүйн тулд үргэлж сэрэмжилж мөн залбирах ёстой; учир нь тэр та нарыг буудай мэт шигшиж болохын тулд “Сатан та нарыг эзэмдэхийг хүсч байна.

19 Тиймийн тул та нар миний нэрээр Эцэгт үргэлж залбирах ёстой;

20 Мөн та нар хүлээж авах болно гэж итгээд, миний нэрээр Эцэгээс гуйх, зөв болох “юу боловч, болгоогтун энэ нь та нарт өгөгдөх болно.

21 Эхнэрүүд хийгээд хүүхдүүд чинь адислагдаж болохын тулд, гэр бүлдээ Эцэгт хандан миний нэрээр үргэлж “залбир.

22 Мөн болгоогтун, та нар ойр ойрхон цуглан уулзацгаах болно; мөн та нар нэг ч хүнийг та нар цуглах үедээ ирэхийг хориглохгүй, харин тэд та нарт ирэхийг тэдэнд зөвшөөрч мөн тэднийг хориглохгүй байх болно;

23 Харин та нар тэдний

12a су Хад.

13a су Урвалт.

б 3 Ниф. 11:39.

15a Алма 34:17–27.

су Залбирал.

16a су Гэрэл, Христийн

гэрэл.

б су Есүс Христ—

Есүс Христийн

Үлгэр жишээ.

18a Лук 22:31;

2 Ниф. 2:17–18;

С ба Г 10:22–27.

20a Мат. 21:22;

Хил. 10:5;

Моро. 7:26;

С ба Г 88:63–65.

21a Алма 34:21.

төлөө “залбирах болно, мөн тэднийг зайлуулахгүй байх болно; мөн хэрэв тэд ойр ойрхон та нарт ирэх аваас та нартэдний төлөө Эцэгт миний нэрээр залбирах болно.

24 Тиймийн тул, дэлхийд туяарч болохын тулд “гэрлээ өргөгтүн. Болгоогтун би бол та нарын өргөх тэрхүү ^бгэрэл билээ — та нарын харсан тэдгээр нь миний үйлдсэн зүйлүүд болой. Болгоогтун Эцэгт хандан залбирахыг минь та нар харсан, мөн та нар бүгдээрээ харсан билээ.

25 Мөн би та нарын “хэнийг нь ч зайлан явахыг та нарт зарлиг болгосонгүй, харин ч эсрэгээр та нар ^бтэмтэрч мөн харж болохын тулд надад ирэхийг та нарт зарлиг болгосоныг та нар харж байна; та нар түүнчлэн дэлхийхэнд үйлдэх болно; мөн энэ зарлигийг эвдсэн хэн боловч тэрбээр өөрийгөө уруу таталганд удирдагдахыг хүлцдэг.

26 Мөн эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр үгийг яриад, тэрбээр өөрийн сонгосон шавь нартаа дахин харцаа хандуулж, мөн тэдэнд хэлэв:

27 Болгоогтун үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, би өөр нэг зарлигийг та нарт өгч байна, мөн тэгээд би надад түүний өгсөн өөр “зарлигуудыг гүйцэлдүүлж

болохын тулд би ^бЭцэгтээ очих ёстой.

28 Мөн эдүгээ болгоогтун, энэ бол та нарт өгөх миний зарлиг, та нар үүнийг адислан түгээхдээ хэн нэгэн миний махбодь болон цусыг “зохисгүйгээр ^бхүртэхийг та нар мэдсээр байж хүлцэж болохгүй;

29 Учир нь миний бие махбодь болон “цусыг ^бзохисгүйгээр идэж мөн уух хэн боловч бодгальдаа ялыг идэж мөн уудаг; тиймийн тул хэрэв хэн нэгэн миний махбодь мөн цусыг идэх мөн уух нь зохистой бусыг та нар мэдэх аваас та нар түүнийг хориглох болно.

30 Гэсэн хэдий ч, та нар түүнийг өөрсдийн дундаас “зайлуулахгүй, харин та нар түүнд тохинуулж мөн миний нэрээр, Эцэгт хандан түүний төлөө залбирах болно; мөн хэрэв тэрбээр наманчилж мөн миний нэрээр баптисм хүртэх аваас, тэгвэл та нар түүнийг хүлээн зөвшөөрч, мөн миний махбодь болон цуснаас түүнд адислан түгээх болно.

31 Харин хэрэв тэр наманчлахгүй аваас тэрбээр миний хүмүүсийг устгаж болохгүйн тулд, тэрбээр миний хүмүүсийн дунд тоологдохгүй, учир нь болгоогтун би “хонинуудаа мэднэ, мөн тэд тоологдсон билээ.

23а 3 Ниф. 18:30.

24а Мат. 5:16.

б Мозая 16:9.

25а Алма 5:33.

б 3 Ниф. 11:14–17.

27а 3 Ниф. 16:1–3.

б су Бурхан, Бурхан тэргүүтэн — Эцэг Бурхан.

28а Морм. 9:29.

б 1 Кор. 11:27–30.

29а су Цус; Ариун

ёслол.

б С ба Г 46:4.

30а С ба Г 46:3.

31а Иохан 10:14;

Алма 5:38;

3 Ниф. 15:24.

32 Гэсэн хэдий ч, та нар түүнийг синагогуудаасаа, эсвэл шүтлэгийн байруудаасаа хөөхгүй, учир нь тийм нэгэнд та нар үргэлжлүүлэн тохионуулах болно; учир нь, тэд эргэж ирээд мөн наманчилж, мөн зүрх сэтгэлийнхээ бүх тэмүүлээр надад ирж мөн би тэднийг “эдгээх ажгуу; мөн та нар тэдэнд авралыг авчрах хэрэгсэл байх эсэхийг та нар мэдэхгүй.

33 Тиймийн тул, та нар “буруушаалтанд өртөхгүйн тулд та нарт миний зарлигласан эдгээр үгсийг дагагтун; учир нь Эцэг буруушаасан түүнд халаг.

34 Мөн та нарын дунд байсан арцалдааны учир би эдгээр зарлигуудыг та нарт өгч байна. Мөн хэрэв та нарын дунд “арцалдаанууд үгүй аваас адислагдсан болой та нар.

35 Мөн эдүгээ би Эцэгт очно, учир нь би “та нарын тусын тулд Эцэгт очих нь зайлшгүй юм.

36 Мөнхүү улиран тохиох дор Есүс эдгээр үгийг төгсгөл болгоод, тэрбээр өөрөө сонгосон “шавь нартаа “гараа хүргэж, нэг нэгээр нь, бүр тэднийг бүгдэд нь хүрэх хүртлээ, мөн тэрбээр тэдэнд хүрэхийн хамтаар тэдэнд ярив.

37 Мөн цугласан олон түүний ярьсан үгсийг сонссонгүй,

тиймийн тул тэд гэрчилсэнгүй; гэвч тэрбээр “Ариун Сүнснийг өгөх хүчийг тэдэнд олгосон хэмээн шавь нар нь гэрчилсэн болой. Мөн энэ цэдэг үнэн гэдгийг би та нарт цаашид үзүүлэх болно.

38 Мөнхүү улиран тохиох дор Есүс тэдэнд бүгдэд нь хүрэхэд, “үүл бууж мөн тэд Есүсийг харж чадахааргүй болгож цугласан олныг сүүдэрлэв.

39 Мөн тэднийг сүүдэрлэгдсэн байхад тэрбээр тэднээс одож, мөн тэнгэрт дээш одов. Мөн шавь нар нь харж мөн тэрбээр тэнгэр өөд дахин дээшлэн одсоныг гэрчлэв.

БҮЛЭГ 19

Арванхоёр шавь хүмүүст тохионуулж мөн Ариун Сүнсний төлөө залбирав — Шавь нар баптисм хүртээж мөн Ариун Сүнснийг мөн тэнгэр элчүүдийн тохиинууллыг хүлээн авав — Есүс бичигдэх аргагүй үгс хэрэглэн залбирав — Тэрбээр эдгээр нифайчуудын үлэмж агуу итгэлийг гэрчлэв. Ойролцоогоор мэ 34 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Есүсийг тэнгэрт дээшлэн одоход, цугласан олон тархав, мөн хүн бүр эхнэрээ мөн хүүхдүүдээ авч мөн гэртээ эргэж харив.

32a 3 Ниф. 9:13–14;

С ба Г 112:13.

33a су Яллах, Ял.

34a 3 Ниф. 11:28–30.

35a 1 Иохан 2:1;

2 Ниф. 2:9;

Моро. 7:27–28;

С ба Г 29:5.

36a су Гар тавих.

б 1 Ниф. 12:7;

3 Ниф. 19:4.

37a су Ариун Сүнсний бэлэг.

б су Хүч.

38a Ег. 19:9, 16.

2 Мөн цугласан олон Есүсийг харсан, мөн тэрбээр тэдэнд тохинуулсан, мөн тэрбээр түүнчлэн маргааш нь цугласан олонд өөрийгөө үзүүлэх болно гэсэн нь тэр даруй харанхуй болохоос өмнө хүмүүсийн дунд тархан сонсогдов.

3 Тийм ээ, мөн бүр бүхэл шөнөжингөө Есүсийн талаар тархан сонсогдов; мөн үүний хэрээр тэд хүмүүст дамжуулснаас тэнд олон нь байв, тийм ээ, үлэмж их тоотой, тэд маргааш нь Есүс өөрийгөө цугласан олонд үзүүлэх тэр газар байж болохын тулд бүхэл шөнөжингөө үлэмж шаргуу хөдөлмөрлөв.

4 Мөнхүү улиран тохиох дор маргааш нь, олон түмнийг нэгдэн цугларахад, болгоогтун, Нифай мөн нас барагсдаас түүний босгосон, нэр нь Тимофи гэдэг дүү нь, мөн түүнчлэн нэр нь Жонас асан түүний хүү, мөн түүнчлэн Мафони, мөн түүнчлэн Мафонайха, түүний дүү, мөн Күмен, мөн Күменонхай, мөн Иеремиа, мөн Шемнон, мөн Жонас, мөн Зедикая, мөн Исаиа — эдүгээ тэд бол Есүсийн сонгосон шавь нарынх нь нэрс байв — мөнхүү улиран тохиох дор тэд явж мөн цугласан олны дунд зогсов.

5 Мөн болгоогтун, цугласан олон тийм агуу байснаас тэднийг арванхоёр хэсэгт

тусгаарлагдсан байхаар тэд болгов.

6 Мөнхүү арванхоёр цугласан олонд заав; мөн болгоогтун, тэд цугласан олныг газрын гадаргуу дээр доош сөхөрч, мөн Есүсийн нэрээр Эцэгт хандан залбирах болгов.

7 Мөнхүү шавь нар нь түүнчлэн Есүсийн нэрээр Эцэгт хандан залбирав. Мөнхүү улиран тохиох дор тэд босож мөн хүмүүст тохинуулав.

8 Мөн тэд Есүсийн ярьсны нэгэн адил үгсээр тохинуулсны дараа — Есүсийн ярьсан үгсээс юу ч зөрүүлэхгүйгээр — болгоогтун, тэд дахин сөхөрч мөн Есүсийн нэрээр Эцэгт хандан залбирав.

9 Мөн тэд хамгийн их хүссэн түүнийхээ төлөө залбирав; мөн “Ариун Сүнс өөрсдөд нь өгөгдөхийг тэд хүсэв.

10 Мөн тэд тийн залбираад тэд уруудан усны захад очиход, мөн цугласан олон тэднийг дагав.

11 Мөнхүү улиран тохиох дор Нифай “ус уруу орж мөн баптисм хүртэв.

12 Мөн тэрбээр уснаас гарч ирээд мөн баптисм хүртээж эхлэв. Мөн тэрбээр Есүсийн сонгосон тэд бүгдэд баптисм хүртээв.

13 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгд “баптисм хүртэхэд мөн уснаас гарч ирэхэд, Ариун Сүнс тэдний дээр бууж, мөн тэд “Ариун Сүнсээр мөн галаар дүүргэгдэв.

19 9a 3 Ниф. 9:20.
11a 3 Ниф. 11:23.
13a су Баптисм,

Баптисм хүртээх.
б 3 Ниф. 12:2;
Морм. 7:10.

су Ариун Сүнсний
бэлэг.

14 Мөн болгоогтун, тэд “галаар лугаа адил хүрээлэгдэв, мөн энэ нь тэнгэрээс бууж ирсэн аж, мөн цугласан олон үүнийг үзэж, мөн гэрчлэв; мөн тэнгэр элчүүд тэнгэрээс бууж ирээд мөн тэдэнд тохинуулав.

15 Мөнхүү улиран тохиох дор тэнгэр элчүүд шавь нарт нь тохинуулж байх зуур, болгоогтун, Есүс ирж мөн дунд нь зогсоод мөн тэдэнд тохинуулав.

16 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр цугласан олонд ярьж, мөн тэдэнд дахин газарт сөхрөхийг, мөн түүнчлэн шавь нараа газарт сөхрөхийг зарлиг болгов.

17 Мөнхүү улиран тохиох дор тэднийг бүгд газарт сөхрөхөд, тэрбээр шавь нартаа тэд залбирахыг зарлиг болгов.

18 Мөн болгоогтун, тэд залбирч эхлэв; мөн түүнийг өөрсдийн Их Эзэн мөн өөрсдийн Бурхан хэмээн дуудаж тэд Есүст залбирав.

19 Мөнхүү улиран тохиох дор Есүс тэдний дундаас одож, мөн тэднээс бага зэрэг холдоод мөн доош бөхийн, мөн тэрээр хэлэв:

20 Эцэг минь, миний сонгосон эдэнд Ариун Сүнсийг өгсөнд тань танд талархъя; мөн надад итгэх тэдний итгэлийн учир би тэднийг дэлхийнхнээс сонгосон билээ.

21 Эцэг минь, тэдний үгсэд итгэх тэр бүгдэд Ариун Сүн-

сийг өгөөч хэмээн би танд залбирна.

22 Эцэг минь, тэд надад итгэдэг учир та тэдэнд Ариун Сүнсийг өгсөн билээ; мөн тэд надад залбирч буйг та сонсож байгаа учир тэд надад итгэдгийг та харж байна; мөн би тэдэнтэй хамт байгаа учраас тэд надад хандан залбирч байна.

23 Мөн эдүгээ Эцэг минь, тэдний төлөө, мөн түүнчлэн тэдний үгсэд итгэх тэд бүгдийн төлөө, тэд надад итгэж болохын тулд, “Эцэг минь, та надад байдгийн адил, би тэдэнд байж болохын тулд, бид ^бнэг байж болохын тулд би танд хандан залбирч байна.

24 Мөнхүү улиран тохиох дор Есүс ийн Эцэгт залбираад, тэрбээр шавь нартаа ирж, мөн болгоогтун, тэд зогсолтгүйгээр бас л үргэлжлүүлэн түүнд залбирсаар байв; мөн тэд “олон үг нуршсангүй, учир нь тэд юу гэж ^бзалбирах нь тэдэнд өгөгдсөн байв, мөн тэд хүслээр дүүргэгдэв.

25 Мөнхүү улиран тохиох дор тэд түүнд хандан залбирах үед Есүс тэднийг адислав; мөн түүний дүр тэдний дээр инээмсэглэж, мөн түүний “дүр төрхийн гэрэл тэдний дээр гийгүүлж, мөн болгоогтун тэд Есүсийн төрх болон түүний өмсгөл лугаа адил ^бцагаан байлаа; мөн болгоогтун тэдний цагаан нь цагаан

14а Хил. 5:23–24, 43–45;

3 Ниф. 17:24.

23а 3 Ниф. 9:15.

б Иохан 17:21–23.

су Эв нэгдэл.

24а Мат. 6:7.

б С ба Г 46:30.

25а Тоол. 6:23–27.

б су Зөөгдөлт—

Зөөгдсөн хүмүүн биес.

бүхнээс үлэмж байв, тийм ээ, бүр түүний цагаан шиг тийм цагаан юм юу ч дэлхийд байх аргагүй билээ.

26 Мөн Есүс тэдэнд хэлэв: Үргэлжлүүлэн залбирагтун; мөнхүү тэгээд тэд залбирахаа зогссонгүй.

27 Мөн тэрбээр тэднээс дахин эргэж, мөн бага зэрэг холдоод мөн доош бөхийж; мөн тэрбээр дахин Эцэгт хандан залбирч, хэлсэн нь:

28 Эцэг минь, итгэлийнх нь учир миний сонгосон тэднийг “ариусгасанд тань талархъя, мөн би тэдний төлөө, тэд надаар ариусгагдсантай адил, тэдний үгсэд итгэх итгэлээрээ дамжуулан тэд надаар ариусгагдаж болохын тулд мөн түүнчлэн тэдний үгсэд итгэх тэдний төлөө залбирч.

29 Эцэг минь, дэлхийн төлөө бус, харин “дэлхийгээс тэдний итгэлийн учир надад таны өгсөн тэдний төлөө, тэд надаар ариусгагдаж болохын тулд, Эцэг минь, та надад байдгийн адил, би тэдэнд байж болохын тулд, бид нэг байж болохын тулд, би тэднээр алдаршуулагдаж болохын тулд би залбирч байна.

30 Мөн Есүс эдгээр үгсийг яриад тэрбээр шавь нартаа дахин ирэв; мөн болгоогтун тэд зогсолтгүйгээр түүнд хандан тууштайгаар залбирсаар байв; мөн тэрбээр тэдний

дээр дахин инээмсэглэв; мөн болгоогтун тэд бүр Есүс шиг “цагаан байв.

31 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр дахин бага зэрэг холдоод мөн Эцэгт хандан залбирав;

32 Мөн түүний залбирсан үгсийг хэлээр өгүүлэх аргагүй, бас түүний залбирсан үгс хүмүүнээр “бичигдэх аргагүй байлаа.

33 Мөн цугласан олон сонсон мөн гэрчилдэг билээ; мөн тэдний зүрх сэтгэл нээлттэй байж мөн тэд түүний залбирсан үгсийг зүрх сэтгэлдээ ойлгосон болой.

34 Гэсэн хэдий ч, тэдгээр нь бичигдэх аргагүй бас тэдгээр нь хүмүүнээр “хэлэгдэх аргагүй түүний залбирсан үгс нь тийм агуу хийгээд гайхамшигтай байв.

35 Мөнхүү улиран тохиох дор Есүс залбирлаа төгсгөл болгоод тэрбээр шавь нартаа дахин ирж, мөн тэдэнд хэлэв: Бүх иудейчүүдийн дунд ийм агуу “итгэл би хэзээ ч үзээгүй; иймийн тул тэдний “итгэлгүйн учир би тэдэнд ийм агуу гайхамшгуудыг үзүүлж чадаагүй билээ.

36 Үнэнээр би та нарт хэлнэ, та нарын үзсэн шиг ийм агуу зүйлийг үзсэн нь тэдний дунд нэг ч үгүй; бас та нарын сонсон шиг ийм агуу зүйлийг тэд сонсоогүй билээ.

28a Моро. 7:48;
С ба Г 50:28–29;
88:74–75.
су Цэвэр ариун,
Цэвэр ариун

байдал.
29a Иохан 17:6.
30a Мат. 17:2.
32a С ба Г 76:116.
34a 2 Кор. 12:4;

3 Ниф. 17:17.
35a су Итгэл.
б Мат. 13:58.
су Итгэлгүй байдал.

БҮЛЭГ 20

Есүс талх, дарсыг гайхамшиг-тайгаар хангаж мөн дахин уг хүмүүст ариун ёслолыг адислан түгээв—Иаковын үлдэгдэл Их Эзэн өөрсдийн Бурханы мэдлэгт ирж мөн Америкийн эх газруудыг өвлөх болно—Есүс бол Мосегийн адил байх тэрхүү бошиглогч, мөн нифайчууд бошиглогчдын хүүхдүүд мөн—Их Эзэний хүмүүсийн бусад зарим нь Иерусалимд цуглуулагдах болно. Ойролцоогоор мэ 34 он.

Мөнхүү улиран тохиох дор тэрбээр цугласан олонд мөн түүнчлэн шавь нартаа тэд залбирахаа зогсохыг зарлиг болгов. Мөн тэрбээр зүрх сэтгэлдээ тэд “залбирахаа үл зогсохыг тэдэнд зарлиг болгов.

2 Мөн тэрбээр тэд өндийж мөн хөл дээрээ зогсохыг тэдэнд зарлиг болгов. Мөн тэд өндийж мөн хөл дээрээ зогсоцгоов.

3 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр дахин талх хувааж мөн үүнийг адислав, мөн шавь нартаа идүүлэхээр өгөв.

4 Мөн тэдгээрийг идэхэд тэд талхыг хувааж, мөн цугласан олонд өгөхийг тэдэнд тэрбээр зарлиглав.

5 Мөн тэд цугласан олонд өгөхөд тэрбээр түүнчлэн тэдэнд дарс уулгахаар өгөв, мөн

цугласан олонд тэд өгөхийг тэдэнд зарлиглав.

6 Эдүгээ шавь нараар нь ч, бас цугласан олноор ямар ч “талх бас дарс ч авчрагдсан байсангүй;

7 Гэвч тэрбээр үнэхээр тэдэнд идэх талх, мөн түүнчлэн уух дарс “өгөв.

8 Мөн тэрбээр тэдэнд хэлэв: Энэ талхыг “идэх тэр нь өөрийн бодгалийн төлөө миний биеийг идэх ажгуу; мөн энэ дарсыг уух тэр нь өөрийн бодгальд миний цусыг уух ажгуу; мөн түүний бодгаль хэзээ ч өлсөж, бас цангахгүй, харин ханасан байх болно.

9 Эдүгээ, цугласан олон бүгд идэж мөн уухад, болгоогтун, тэд Сүнсээр дүүргэгдэв; мөн тэд нэгэн дуугаар хашгирч, мөн тэд өөрсдийн харсан бас сонссон, Есүсийг магтан дуулав.

10 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгд Есүсийг магтан дуулсны дараа, тэрбээр тэдэнд хэлэв: Болгоогтун эдүгээ Израилын угсааны үлдэгдэл болох энэ хүмүүсийн талаар Эцэг надад зарлиг болгосон тэрхүү зарлигийг би гүйцээлээ.

11 Та нарт миний ярьсныг, мөн “Исаиагийн “үгс гүйцэлдэх тэр үед юу болохыг хэлснийг та нар санаж байгаа—болгоогтун тэдгээр нь бичигдсэн байгаа, тэдгээр нь та

20 1a 2 Ниф. 32:9;
Мозая 24:12.
6a Мат. 14:19–21.
7a Иохан 6:9–14.

8a Иохан 6:50–58;
3 Ниф. 18:7.
су Ариун ёслол.
11a 2 Ниф. 25:1–5;

Морм. 8:23.
б 3 Ниф. 16:17–20;
23:1–3.

нарт өмнө чинь байна, тиймийн тул тэдгээрийг судал—

12 Мөн үнэнээр, үнэнээр, би та нарт хэлье, тэдгээр нь гүйцэлдэх үед тэгээд өөрийн хүмүүстэй, Ай Израилын угсаатай Эцэгийн хийсэн “гэрээ гүйцэлдэх болно.

13 Мөн тэгээд газрын гадаргуу дээр “тархан тараагдах ^бүлдэгдлүүд дорнодоос бас өрнөдөөс, мөн өмнөдөөс бас умардаас “цуглуулагдах болно; мөн тэднийг гэтэлгэсэн, Их Эзэн Бурханыхаа “мэдлэгт тэд авчрагдах болно.

14 Мөн би та нарт энэ “нутгийг та нарын өв болгон өгөхийг Эцэг надад зарлиг болгосон юм.

15 Мөн би та нарт хэлье, тэд миний хүмүүсийг тараасны дараа, тэдний хүлээн авах тэрхүү адислалын дараа хэрэв харийнхан “наманчлахгүй аваас—

16 Тэгвэл Иаковын угсааны үлдэгдэл болох та нар, тэдний дунд явах болно; мөн та нар олон байх тэдний дунд байх болно; мөн та нар тэдний дунд хөвчийн амьтдын дундах арслан лугаа адил, хонин сүрэг дундах залуу “арслан лугаа адил байх болно хэрэв тэр дундуур нь явах аваас доош ^бдэвсэлж мөн хэдэн хэсэг тасчих ажгуу, мөн хэн ч чөлөөлж чадахгүй.

17 Гар тань өрсөлдөгчийн чинь дээр далайгдаж, мөн бүх дайсан чинь зайлуулагдах болно.

18 Мөн хүмүүн тарианы боодлуудыг саравчинд цуглуулдаг шиг би өөрийн хүмүүсийг “нэгтгэн цуглуулах болно.

19 Учир нь Эцэгийн гэрээ хийсэн өөрийн хүмүүсийг би, тийм ээ, би та нарын “эврийг чинь төмөр, мөн туурайг чинь гууль болгоно. Мөн та нар олон хүмүүнийг хэдэн хэсэг болгон цохих болно; мөн би Их Эзэний төлөө тэдний баялгийг, мөн бүх дэлхийн Их Эзэний төлөө тэдний эд хөрөнгийг ариулан адислах болно. Мөн болгоогтун, үүнийг хийх тэр нь би билээ.

20 Мөнхүү улиран тохиох дор, Эцэг хэлэв, тэр өдөр миний шударга ёсны “илд тэдний дээр далайгаастай байх болно; мөн тэд наманчлахгүй аваас энэ нь тэдний дээр, тийм ээ, бүр харийнханы бүх үндэстнүүдийн дээр буух болно хэмээн Эцэг хэлэв.

21 Мөнхүү улиран тохиох дор би өөрийн “хүмүүсийг, Ай Израилын угсааг төвхнүүлэх болно.

22 Мөн болгоогтун, би та нарын өвөг Иаковтай хийсэн гэрээг “гүйцэлдүүлэхийн тулд,

12a 3 Ниф. 15:7–8.

13a 3 Ниф. 16:11–12; 21:2–7.

б су Израил—

Израилын

Тараагдалт.

в су Израил—

Израилын

цугларалт.

г 3 Ниф. 16:4–5.

14a су Амлалтын нутаг.

15a 3 Ниф. 16:10–14.

16a Морм. 5:24;

С ба Г 19:27.

б Мика 5:8–9;

3 Ниф. 16:14–15; 21:12.

18a Мика 4:12.

19a Мика 4:13.

20a 3 Ниф. 29:4.

21a 3 Ниф. 16:8–15.

22a Эхл. 49:22–26;

С ба Г 57:2–3.

би энэ хүмүүсийг энэ нутагт төвхнүүлэх болно; мөн энэ нь ⁶Шинэ Иерусалим байх болно. Мөн тэнгэрийн хүч энэ хүмүүсийн дунд байх болно; тийм ээ, бүр ⁶би та нарын дунд байх болно.

23 Болгоогтун, би бол Мосегийн тухайлан ярьж, хэлсэнчлэн: Их Эзэн Бурхан тань та нарт ах дүүсээс тань миний адил ⁶бошиглогчийг бий болгох болно; та нарт түүний хэлэх юуг боловч, бүх зүйлийн хувьд түүнийг та нар сонсох болно. Мөнхүү улиран тохиох дор тэр бошиглогчийг анхааран сонсохгүй бодгаль болгон, хүмүүсийн дундаас тусгаарлагдах болно.

24 Үнэнээр би та нарт хэлье, тийм ээ, мөн Самуелаас эхлээд дараачийн ⁶бүх бошиглогчид, ярьсан болгон нь, миний тухай гэрчилсэн билээ.

25 Мөн болгоогтун, та нар бол бошиглогчдын хүүхдүүд; мөн та нар бол Израилын угсааных; мөн Абрахамд хэлсэн нь: Мөн чиний ⁶үр удмаар дэлхийн бүх үндэстнүүд адислагдах болно хэмээн, та нарын эцэг өвгөдтэй Эцэгийн хийсэн ⁶гэрээнийх болой та нар.

26 Эцэг та нарын төлөө намайг түрүүнд нь босгосон, мөн та нарын хүн нэг бүрийг

алдсуудаас нь ⁶эргүүлснээр адислахын тулд намайг илгээсэн; мөн та нар гэрээний хүүхдүүд учраас энэ юм —

27 Мөн та нарыг адислагдсаны дараа тэгээд Эцэг, хэлсэн нь: ⁶Чиний үр удмаар дамжин дэлхийн бүх үндэстэн адислагдах болно хэмээн Абрахамтай хийсэн гэрээгээ тэрбээр гүйцэлдүүлэх ажгуу — ингэснээр надаар дамжуулан ⁶харийнхан дээр Ариун Сүнснийг цутган юүлснээс харийнхан дээрх энэхүү адислал тэднийг бүхнээс дээгүүр хүчирхэг болгосноор, миний хүмүүсийг, Ай Израилын угсааг тараах болно.

28 Мөн тэд энэ нутгийн хүмүүст ⁶цээрлэл байх болно. Гэсэн хэдий ч, тэд миний сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авсны дараа, тэгээд хэрэв тэд миний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулах аваас би тэдний алдсуудыг өөрсдийнх нь толгой дээр хариулах болно хэмээн Эцэг хэлдэг.

29 Мөн би өөрийн хүмүүстэй хийсэн тэрхүү гэрээг ⁶санах болно; мөн ⁶Иерусалимын нутаг болох, Эцэгийн хэлснээр тэдэнд үүрд амлагдсан нутаг болох тэрхүү эцэг өвгөдийнх нь ⁶нутгийг тэдний өв болгон

22б Иса. 2:2–5;
3 Ниф. 21:23–24;
Ифер 13:1–12;
С ба Г 84:2–4.
су Шинэ
Иерусалим.
в Иса. 59:20–21;
Малах. 3:1;
3 Ниф. 24:1.

23а Дэд хууль 18:15–19;
Үйлс 3:22–23;
1 Ниф. 22:20–21.

24а Үйлс 3:24–26;
1 Ниф. 10:5;
Иаков 7:11.

25а Эхл. 12:1–3; 22:18.

б су Абрахамын Гэрээ.
26а Сур. үгс 16:6.

27а Гал. 3:8;
2 Ниф. 29:14;
Абр. 2:9.
б 3 Ниф. 16:6–7.
28а 3 Ниф. 16:8–9.
29а Иса. 44:21;
3 Ниф. 16:11–12.
б су Иерусалим.
в Амос 9:14–15.

дахин өгөх болно хэмээн, өөрийн зохих цагт би тэднийг цуглуулах болно хэмээн би тэдэнтэй гэрээ хийсэн бөлгөө.

30 Мөнхүү улиран тохиох дор сайн мэдээний минь бүрэн байдал тэдэнд номлогдох цаг ирэх болно;

31 Мөн би бол Есүс Христ, Бурханы Хүү гэдэгт тэд надад “итгэх болно, мөн миний нэрээр Эцэгт хандан залбирах болно.

32 Тэгээд тэдний “харуулууд дуугаа өргөн, мөн нэгэн дуугаар хамтдаа тэд дуулах болно; учир нь тэд нүдээрээ харах болно.

33 Тэгээд Эцэг тэднийг дахин нэгтгэн цуглуулж, мөн тэдний өвлөх нутаг болгон Иерусалимыг тэдэнд өгөх болно.

34 Тэгээд тэд баясан дуу алдах болно — Хамтдаа “дуулцгаа, Иерусалимын зэлүүд газрууд та нар; учир нь Эцэг өөрийн хүмүүсийг тайтгаруулж, тэрбээр Иерусалимыг гэтэлгэв.

35 Эцэг бүх үндэстнүүдийн нүдэнд ариун мутраа харуулсан билээ; мөн дэлхийн бүх хязгаарууд Эцэгийн авралыг харах болно; мөн Эцэг бид хоёр нэг юм.

36 Мөн тэгээд бичиглэгдсэн нь: “Сэрэгтүн, дахин сэрэгтүн, мөн хүч чадлаа авагтун, Ай

Сион; гоёмсог өмсгөлөө өмс, Ай Иерусалим, ариун хот, учир нь цаашид хөвч хөндүүлээгүй мөн цэвэр бус нь чамд дахин үл орох болно гэсэн нь тохион авчрагдах болно.

37 Шороо тоосоо сэгсэр; босоод суу, Ай Иерусалим; хүзүүн дэх хүлээснээсээ өөрийгөө сулла, Ай Сионы боолчлогдогч охин.

38 Учир нь Их Эзэн ийн хэлдэг: Та нар өөрсдийгөө юунаас ч бус худалдсан, мөн та нар мөнгөгүйгээр гэтэлгэгдэх болно.

39 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, миний хүмүүс нэрийг минь мэдэх болно; тийм ээ, тэр өдөр ярих тэр нь би байдгийг тэд мэдэх болно.

40 Мөн тэгээд тэд хэлэх болно: Баярт мэдээг тэдэнд авчрах; амар амгаланг “тунхаглах; сайны тухай баярт мэдээг тэдэнд авчрах; авралыг тунхаглах; Таны Бурхан засаглах болно хэмээн Сионд хэлэх түүний хөл уулсын дээр^б хичнээн үзэсгэлэнтэй билээ!

41 Мөн тэгээд хашгирах нь: “Зайлан одогтун, зайлан одогтун, та нар тэндээс гарагтун, “цэвэр бус тэр зүйлд бүү хүр; түүний дундаас та нар гарагтун; Их Эзэний савуудыг тээгч болох та нар “цэвэр ариун байгтун.

29_г су Израил—
Израилын
цугларалт.

31_а 3 Ниф. 5:21–26;
21:26–29.

32_а Иса. 52:8;
3 Ниф. 16:18–20.

су Харах, Харуул.

34_а Иса. 52:9.

36_а Иса. 52:1–3;

С ба Г 113:7–10.

су Сион.

40_а Марк 13:10;

1 Ниф. 13:37.

б Иса. 52:7; Нахум 1:15;

Мозая 15:13–18;

С ба Г 128:19.

41_а Иса. 52:11–15.

б су Цэвэр болон

Цэвэр бус байдал.

в С ба Г 133:5.

42 Өөрөөр хэлбэл та нар “яарч бас зугтаж гарахгүй; учир нь Их Эзэн та нарын өмнө явна, мөн Израилын Бурхан та нарын ар талын хамгаалалт байх болно.

43 Болгоогтун, үйлчлэгч минь ухаалгаар үйлдэх болно, тэрбээр өргөмжлөгдөн мөн магтагдаж мөн их өндөрт байх болно.

44 Олон нь чамайг хараад гайхан балмагдсан байв— түүний төрх ямар ч хүнийхээс илүүтэй, мөн түүний бие хүмүүний хөвгүүдийнхээс илүүтэй зэрэмдэглэгдсэн билээ—

45 Иймээс тэрбээр олон үндэстнийг “шүрших болно; хаад түүний улмаас амаа хамхих болно, учир нь тэдэнд хэлэгдээгүйг тэд үзэх болно; мөн тэдэнд дуулдаагүйг тэд ухаарах.

46 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, эдгээр бүх зүйл, яг Эцэг надад зарлиг болсны дагуу гарцаагүй ирэх болно. Тийнхүү өөрийн хүмүүстэй Эцэгийн хийсэн энэхүү гэрээ гүйцэлдэх болно; мөн тэгээд “Иерусалим миний хүмүүсээр дахин эзэмшигдэх болно, мөн энэ нь тэдний өвийн нутаг байх болно.

БҮЛЭГ 21

Мормоны Ном ирэхэд Израил цуглуулагдах болно—Харийнхан Америкт чөлөөт хүмүүс болж

төвхнүүлэгдэх болно—Тэд хэрэв итгэж мөн дуулгавартай байх аваас тэд аврагдах болно; эс тэгвээс тэд тусгаарлагдаж мөн устгагдах болно—Израил Шинэ Иерусалимыг барих болно, мөн төөрөлдсөн овгууд эргэж ирэх болно. Ойролцоогоор мэ 34 он.

Мөн үнэнээр би та нарт хэлнэ, эдгээр зүйл тохиох нь ойртох “цагийг та нар мэдэж болохын тулд би та нарт нэгэн тэмдэг өгье—үүнд би өөрийн хүмүүсийг, Ай Израилын угсааг удаан хугацааны тараагдалтаас нь дотогш цуглуулах болно, мөн тэдний дунд өөрийн Сионыг дахин байгуулах болно;

2 Мөн болгоогтун, энэ нь та нарт миний тэмдэг болгон өгөх тэр зүйл билээ—учир нь үнэнээр би та нарт хэлнэ, Иаковын угсааны үлдэгдэл болох энэ хүмүүсийн талаар, мөн өөрсдөөр нь тараагдах миний энэ хүмүүсийн талаар тэд мэдэж болохын тулд та нарт миний тунхаглаж байгаа, мөн та нарт миний цаашид ч өөрийн биеэр мөн Эцэгээр та нарт өгөгдөх Ариун Сүнсний хүчээр тунхаглах эдгээр зүйлүүд харийнханд мэдүүлэгдэх тэр үед;

3 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, “эдгээр зүйлүүд Эцэгээр тэдэнд мэдэгдэх болно, мөн та нарт тэднээс Эцэгээр ирүүлэгдэх тэр үед;

4 Учир нь тэд энэ нутагт

42a 3 Ниф. 21:29.
45a Иса. 52:15.
46a Ифер 13:5, 11.

21 1a су Эцсийн өдрүүд, Хожмын өдрүүд.

3a Ифер 4:17;
ИС—Т 1:34–36.

төвхнүүлэгдэж, мөн Эцэгийн хүчээр “чөлөөт хүмүүс болгогдох нь Эцэгийн мэргэн ухаан, өөрийн хүмүүстэй, Ай Израилын угсаатай хийсэн Эцэгийн ⁶гэрээ гүйцэлдэж болохын тулд эдгээр зүйлүүд тэднээс та нарын үр удмын үлдэгдэлд ирж болохын тулд буюу;

5 Тиймийн тул, эдгээр ажлууд, мөн цаашид та нарын дунд хийгдэх тэрхүү ажлууд “харийнханаас, алдсын учир итгэлгүйдээ бууран доройтох тэрхүү ⁶үр удамд чинь ирэх тэр үед;

6 Учир нь тийн энэ нь “харийнханаас ирэх нь Эцэгийн таалал байв, тэрбээр өөрийн хүчийг харийнханд үзүүлж болохын тулд бөлгөө; хэрэв харийнхан зүрх сэтгэлээ хатууруулахгүй аваас, тэд ⁶миний хүмүүсийн, Ай Израилын угсааны дунд тоологдож болно гэсэн энэхүү шалтгааны улмаас тэд наманчилж мөн надад ирж, мөн миний нэрээр баптисм хүртэж мөн сургаалын минь заалтыг мэдэж болох бөлгөө;

7 Мөн эдгээр зүйлүүд улиран тохиоход чиний “үр удам эдгээр зүйлийг мэдэж эхлэх болно—тэд Израилын угсааных болох хүмүүст түүний хийсэн гэрээг гүйцэлдүүлэ-

хээр Эцэгийн тэрхүү ажил аль хэдийн эхэлснийг тэд мэдэж болохын тулд энэ нь тэдэнд тэмдэг байх болно.

8 Мөн тэр өдөр ирэхэд, улиран тохиох дор хаад түүний улмаас амаа хамжих болно; учир нь тэдэнд хэлэгдээгүйг тэд үзэх болно; мөн тэдэнд дуулдаагүйг тэд ухаарах болно.

9 Өөрөөр хэлбэл тэр өдөр, миний тусын тулд Эцэг тэдний дундах “агуу хийгээд гайхамшигт байх ажлыг үйлдэх болно; мөн хэдийгээр нэгэн хүмүүн үүнийг тэдэнд тунхаглах боловч үүнд итгэхгүй тэд тэдний дунд байх болно.

10 Гэвч болгоогтун, миний үйлчлэгчийн амь гарт минь байх болно; тиймийн тул тэдний улмаас тэрбээр “зэрэмдэглэгдэх хэдий ч тэд түүнийг гэмтээхгүй болой. Гэсэн хэдий ч би түүнийг эдгээх болно, учир нь ⁶миний мэргэн ухаан чөтгөрийн башир аргаас илүү агууг би тэдэнд үзүүлэх болно.

11 Тиймийн тул улиран тохиох дор, Эцэг түүнд авчрах хүчийг өгч, харийнханд “түүгээр авчруулах, Есүс Христ болох миний үгсэд итгэхгүй хэн боловч, (энэ нь яг Мосегийн хэлсэнчлэн хийгдэх болно) тэд гэрээнийх болох

4а 1 Ниф. 13:17–19;
С ба Г 101:77–80.
б Морм. 5:20.
су Абрахамын гэрээ.
5а 3 Ниф. 26:8.
б 2 Ниф. 30:4–5;
Морм. 5:15;
С ба Г 3:18–19.

6а 1 Ниф. 10:14;
Иаков 5:54;
3 Ниф. 16:4–7.
б Гал. 3:7, 29;
3 Ниф. 16:13;
Абр. 2:9–11.
7а 3 Ниф. 5:21–26.
9а Иса. 29:13; Үйлс

13:41; 1 Ниф. 22:8.
су Сайн Мэдээний сэргээлт.
10а С ба Г 135:1–3.
б С ба Г 10:43.
11а 2 Ниф. 3:6–15;
Морм. 8:16, 25.

миний хүмүүсийн дундаас ^бтусгаарлагдах болно.

12 Мөн Иаковын үлдэгдэл болох миний хүмүүс харийнханы дунд буй, тийм ээ, тэдний дунд хөвчийн амьтдын дундах “арслан лугаа адил, хонин сүрэг дундах залуу арслан лугаа адил байх болно, хэрэв тэр дундуур нь явах аваас ^бдоош дэвсэлж мөн хэдэн хэсэг тасчина, мөн хэн ч чөлөөлж чадахгүй.

13 Гар тань өрсөлдөгчийн чинь дээр далайгдах ажгуу, мөн бүх дайснууд чинь зайлуулагдах болно.

14 Тийм ээ, тэд “наманчлахгүй аваас харийнханд халаг болог; учир нь улиран тохиох дор тэр өдөр, Эцэг хэлнэ, би морьдыг чинь та нарын дундаас устган зайлуулах болно, мөн би тэрэгнүүдийг чинь устгах болно;

15 Мөн би нутгийн чинь хотуудыг тусгаарлана, мөн бүх бэхлэлтүүдийг чинь доош унагах болно;

16 Мөн би чиний нутгаас шулмын аргыг тусгаарлах болно, мөн чамд зөгнөн хэлэгч дахин үгүй байх болно;

17 Чиний “зормол шүтээнүүдийг мөн та нарын дундаас босоо шүтээнүүдийг тань би түүнчлэн тусгаарлах болно, мөн та нар өөрийн гарын ажлуудаа цаашид шүтэх ёсгүй;

18 Мөн та нарын дундаас би ойн цоорхойнуудыг чинь суга татах болно; тэрчлэн би хотуудыг чинь устгах болно.

19 Мөнхүү улиран тохиох дор бүх “худал, мөн хуурмаг, мөн атаа жетөө, мөн хэрүүл маргаан, мөн санваараар мэргэших явдал, мөн садар самуун үгүй болох болно.

20 Учир нь улиран тохиох дор, Эцэг хэлсэн нь, тэр өдөр наманчлахгүй мөн Хайрт Хүүд минь ирэхгүй хэнийг боловч, тэднийг би өөрийн хүмүүсийн дундаас, Ай Израилын угсаанаас тусгаарлах болно;

21 Мөн би өс хонзонгоо авч мөн тэдний дээр, бүр буруу номтнуудын дээр лугаа, тэдний сонсоогүй ихээр хилэгнэх болно.

22 Гэвч хэрэв тэд наманчилж мөн миний үгсийг анхааран сонсож, мөн зүрх сэтгэлээ хатууруулахгүй аваас, би өөрийн сүмийг тэдний дунд “байгуулах болно, мөн тэд гэрээнд орж мөн энэ нутгийг өөрсдөд нь өв болгон миний өгсөн Иаковын энэхүү үлдэгдлийн дунд ^бтоологдох болно.

23 Мөн тэд миний хүмүүст, Иаковын үлдэгдэлд, мөн түүнчлэн Израилын угсаанаас ирэх болгонд, тэд “Шинэ Иерусалим гэж нэрлэгдэх нэгэн хотыг барьж болохын тулд тэд туслах болно.

11б С ба Г 1:14.

12а Мика 5:8–15;

3 Ниф. 20:16.

б 3 Ниф. 16:13–15.

14а 2 Ниф. 10:18; 33:9.

17а Ег. 20:3–4;

Мозая 13:12–13;

С ба Г 1:16.

су Хиймэл шүтээн.

19а 3 Ниф. 30:2.

22а су Эрин үе.

б 2 Ниф. 10:18–19;

3 Ниф. 16:13.

23а 3 Ниф. 20:22;

Ифер 13:1–12.

су Шинэ

Иерусалим.

24 Мөн тэгээд бүх нутгийн гадаргуу дээр тараагдсан тэд Шинэ Иерусалимд цуглан ирж болохын тулд тэд миний хүмүүст туслах болно.

25 Мөн тэгээд тэнгэрийн “хүч тэдний дунд бууж ирэх болно; мөн ^бби түүнчлэн дунд нь байх болно.

26 Мөн тэгээд, бүр энэ сайн мэдээ энэ хүмүүсийн үлдэгдлийн дунд номлогдох үед Эцэгийн ажил тэр өдөр эхлэх болно. Үнэнээр би та нарт хэлнэ, тэр өдөр миний хүмүүсийн тараагдсан бүгдийнх нь, тийм ээ, Иерусалимаас Эцэгийн удирдан гаргасан, бүр “төөрөлдсөн овгуудын дунд Эцэгийн ажил ^бэхлэх болно.

27 Тийм ээ, тэд миний нэрээр Эцэгийг дуудаж болохын тулд, тэд түүгээр надад ирж болох замыг бэлтгэхээр уг ажил “тараагдсан миний бүх хүмүүсийн дунд Эцэгээр эхлүүлэгдэх болно.

28 Тийм ээ, мөн тэгээд түүний хүмүүс тэдний өвийн нутаг болох гэртээ түүгээр “цуглуулагдаж болох замыг бэлтгэснээр уг ажлыг бүх үндэстнүүдийн дунд Эцэг эхлүүлэх болно.

29 Мөн тэд бүх үндэстнүүдээс гарах болно; мөн тэд “яарч бас зугтаж гарахгүй, учир нь би тэдний өмнө явах болно, мөн би тэдний ар

талын хамгаалалт байх болно хэмээн Эцэг хэлдэг.

БҮЛЭГ 22

Эцсийн өдрүүдэд, Сион болон түүний гадаснууд байгуулагдах болно мөн нигүүлсэл мөн нинжин сэтгэлд Израил цуглуулагдах болно—Тэд аугаа болно—Исаиагийн 54 дүгээр бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мэ 34 он.

Мөн тэгээд бичигдсэн нь улиран тохиох болно: Ай дуулцгаа, хүүсэр эмэгтэйчүүд, хүүхэд төрүүлээгүй та нар; “дуулж эхэлцгээ, мөн чангаар хашгир, хүүхэд төрүүлэхийн зовлонг үзээгүй та нар; учир нь гэрлээгүй эмэгтэйн хүүхдүүд гэрлэсэн эхнэрийн хүүхдүүдээс илүү олон болно хэмээн Их Эзэн хэлэв.

2 Майхныхаа зайг томсгож, мөн сууцныхаа хөшигнүүдийг дэлгэг тэд; биеэ бүү гамна; аргамжаагаа уртасгаж мөн “гадсаа бөхлөгтүн;

3 Учир нь та баруун гар тийш мөн зүүн тийш хальж, мөн чиний үр удам “харийнханыг өвлөж мөн эзгүйрсэн хотуудыг эзэмшигдэхээр болгоно.

4 Бүү ай, учир нь чи ичгүүрлэгдэхгүй; бас чи шившиглэгдэх нь үгүй, учир нь чи “ичгүүр болгогдохгүй; өөрөөр хэлбэл залуугийнхаа ичин-

25a 1 Ниф. 13:37.

б Иса. 2:2–4;

3 Ниф. 24:1.

26a су Израил—

Израилын алдагдсан арван овог.

б 1 Ниф. 14:17;

3 Ниф. 21:6–7.

27a 3 Ниф. 16:4–5.

28a су Израил—

Израилын цугларалт.

29a Иса. 52:12;

3 Ниф. 20:42.

22 1a су Дуулах.

2a су Гадас.

3a су Харийнхан.

4a 2 Ниф. 6:7, 13.

гүйрлийг чи мартаж болно, мөн залуугийнхаа шившгийг санахгүй, мөн чи бэлэвсрэлийнхээ тухай шившгийг цаашид санахгүй.

5 Учир нь чамайг бий болгогч, чиний эр нөхөр, Түмний Их Эзэн гэдэг нь түүний нэр билээ; мөн чиний Гэтэлгэгч, Израилын Ариун Нэгэн — бүх дэлхийн Бурхан хэмээн тэрбээр нэрлэгдэх болно.

6 Учир нь Их Эзэн чамайг залуу насандаа буцаагдсан эхнэр, орхигдсон мөн сэтгэлдээ гашуудсан эмэгтэй хэмээн дуудсан, Бурхан ийн хэлдэг.

7 Учир нь чамайг түр зуур л орхисон, харин агуу нигүүлсээр би та нарыг цуглуулах болно.

8 Бяцхан хилэгнэлдээ би чамаас түр зуур нүүрээ буруулсан, харин үүрдийн сайхан сэтгэлээр би чамайг “нигүүлсэх болно хэмээн Их Эзэн Гэтэлгэгч чинь хэлдэг.

9 “Энэхэн зуур, миний хувьд Ноагийн ^бус мэт, учир нь би Ноагийн ус дахин газрыг бүрхэхгүй хэмээн тангарагласан лугаа адил, үүнчлэн би чамд хилэгнэхгүй хэмээн тангарагласан бөлгөө.

10 Учир нь “уулс одож мөн толгод зөөгдөх болно, харин миний сайхан сэтгэл чамаас ^бодох нь үгүй, бас миний энх амгалангийн гэрээ хөндөгдөхгүй хэмээн таныг нигүүлсэх тэрхүү Их Эзэн хэлдэг.

11 Ай зүдэрсэн, их салхинд ганхан шидэгдсэн, мөн тайтгаруулагдаагүй чи! Болгоогтун, би өнгөт “чулуугаар барина, мөн суурийг чинь индранилаар барих болно.

12 Мөн цонхнуудыг чинь би гартаамаар, мөн хаалгануудыг чинь нал эрдэнээр, мөн хэрмийг үнэт чулуугаар хийх болно.

13 Мөн “бүх хүүхдүүд чинь Их Эзэнээр сургагдах болно; мөн хүүхдүүдийн чинь амар амгалан агуу байх болно.

14 “Зөв шударга байдалд чи байгуулагдах болно; чи айхгүй учир дарлал хавчлагаас хол байх болно, мөн айдсаас хол байна, учир нь чиний дэргэд энэ нь ирэхгүй.

15 Болгоогтун, тэд гарцаагүй чиний эсрэг надаар бус ч нэгдэн цуглах болно; чиний эсрэг нэгдэн цугласан хэн боловч чиний тусын тулд унах болно.

16 Болгоогтун, ажлынхаа багажийг бүтээхээр нүүрсний галыг хөөрөгдөх дархныг бүтээсэн би; мөн устгахын тулд сүйтгэгчийг бүтээсэн бөлгөө би.

17 Чиний эсрэг бүтээгдсэн ямар ч зэвсэг амжилтанд хүрэхгүй; мөн шүүлтэнд чамайг эсэргүүцэн доромжлох хэн болгоныг чи буруушаах болно. Энэ нь Их Эзэний үйлчлэгчдийн өв, мөн тэдний зөв шударга байдал

8а су Нигүүлсэнгүй,
Нигүүлсэл.

9а Иса. 54:9.

б су Ноагийн үеийн

Үер.

10а Иса. 40:4.

б Дуул. 94:14;

С ба Г 35:25.

11а Илч. 21:18–21.

13а Иер. 31:33–34.

14а су Зөв шударга,

Зөв шударга ёс.

надаас бөлгөө хэмээн Их Эзэн хэлдэг.

БҮЛЭГ 23

Исаиагийн үгсийг Есүс сайшаадаг — Бошиглогчдыг судлахыг тэрбээр хүмүүст зарлиг болгов — Лемен үндэстэн Самуелын Амилуулалтын талаарх үгс тэдний цэдгүүдэд нэмэгдэв. Ойролцоогоор мэ 34 он.

Мөн эдүгээ, болгоогтун, би та нарт хэлнэ, та нар эдгээр зүйлийг “судалбал зохино. Тийм ээ, та нарт миний өгөх нэг зарлиг нь эдгээрийг хичээнгүйлэн судлах юм; учир нь ⁶Исаиагийн үгс агуу билээ.

2 Учир нь гарцаагүйгээр Израилын угсаа болох миний хүмүүсийн талаар бүх зүйлийг тэрээр тухайлан ярьсан юм; тиймийн тул тэрбээр түүнчлэн харийнханд ч ярих ёстой нь зайлшгүй билээ.

3 Мөн түүний ярьсан бүх зүйл, бүр түүний ярьсан үгсийн дагуу “байсаар ирсэн, мөн байх болно.

4 Тиймийн тул миний үгсэд анхаарал тавигтун; та нарт миний хэлсэн зүйлийг бичигтүн; мөн Эцэгийн цаг хугацаа хийгээд тааллын дагуу тэдгээр нь харийнханд очих болно.

5 Мөн үгсийг минь анхааран сонсож мөн наманчилж бас баптисм хүртэх хэн боловч,

чухамхүү тэр нь аврагдах болно. Бошиглогчдыг “судал, учир нь эдгээр зүйлийн талаар гэрчлэх нь олон байдаг.

6 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр үгсийг хэлээд тэрбээр дахин тэдэнд хэлэв, тэрбээр тэдний хүлээж авсан бүх судруудыг тэдэнд тайлбарласныхаа дараа, тэрбээр тэдэнд хэлэв: Болгоогтун, та нарт байхгүй бусад зарим судруудыг та нар бичээсэй хэмээнэ би.

7 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Нифайд хэлэв: Өөрсдийн хөтөлсөн тэр цэдгийг нааш авчрагтун.

8 Мөн Нифай цэдгүүдийг авчирч, мөн тэдгээрийг түүний өмнө тавихад, тэрбээр тэдний зүг хараа бэлчээн мөн хэлэв:

9 Үнэнээр би та нарт хэлнэ, би өөрийн үйлчлэгч болох лемен үндэстэн “Самуелд, тэрбээр энэ хүмүүст Эцэг өөрийн нэрийг надаар алдаршуулах тэр өдөр ⁶олон “гэгээнтэн нас барагсдын дундаас ⁷босно, мөн олонд үзэгдэнэ, мөн тэдэнд тохинуулах болно гэдгийг гэрчлэхийг зарлиг болгосон билээ. Мөн тэрбээр тэдэнд хэлэв: Тийм байгаагүй гэж үү?

10 Мөн шавь нар нь түүнд хариулж мөн хэлэв: Тийм ээ, Их Эзэн, үгсийн тань дагуу Самуел бошиглосон, мөн тэдгээр нь бүгд гүйцэлдсэн.

23 1a су Судрууд.
б 2 Ниф. 25:1–5;
Морм. 8:23.
су Исаиа.

3a 3 Ниф. 20:11–12.
5a Лук 24:25–27.
9a Хил. 13:2.
б Хил. 14:25.

6 су Гэгээнтэн.
7 Мат. 27:52–53.
су Амилуулалт.

11 Мөн Есүс тэдэнд хэлэв: Олон гэгээнтэн босож мөн олонд үзэгдэж мөн тэдэнд тохинуулсныг, энэ зүйлийг та нар яахан үл бичсэн билээ?

12 Мөнхүү улиран тохиох дор Нифай энэ зүйл бичигдээгүйг санав.

13 Мөнхүү улиран тохиох дор Есүс үүнийг бичсүгэй хэмээн зарлиг болов; тиймийн тул энэ нь түүний зарлиг болгосончлон бичиглэгдэв.

14 Мөн эдүгээ улиран тохиох дор Есүс тэдний бичсэн бүх судруудыг нэгтгэн “тайлбарласны дараа, өөрийн тайлбарласан зүйлийг тэд заахыг тэрбээр тэдэнд зарлиг болгов.

БҮЛЭГ 24

Их Эзэний элч Хоёр дахь Ирэлтэнд зориулан замыг бэлтгэх болно—Христ шүүхээр суух болно—Израил арааны нэг болон өргөлийг төлөхөөр зарлиг болгогдов—Дурсамжийн ном хадгалагдав—Малахийн 3 дугаар бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мэ 34 он.

Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Малахид Эцэгийн өгсөн, тэрбээр өөрөө тэдэнд хэлэх үгсийг бичихийг тэдэнд зарлиглав. Мөнхүү улиран тохиох дор тэдгээр нь бичигдсэний дараа тэрбээр тэдгээрийг тайлбарлав. Мөн эдгээр

нь тэдэнд түүний хэлсэн үгс билээ, хэлсэн нь: Эцэг тийн Малахид хэлж өгүүлсэн нь—Болгоогтун, би өөрийн “элчийг илгээх болно, мөн тэрбээр миний өмнө замыг бэлтгэж, мөн та нарын эрэлхийлэх тэрхүү Их Эзэн, бүр түүнд баясах та нарын гэрээний тэрхүү элч гэнэт өөрийн ариун сүмд ирэх болно; болгоогтун, тэрбээр ирэх болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг ажгуу.

2 Гэвч хэн түүний ирэлтийн өдрийг “тэсвэрлэж, мөн түүнийг хүрч ирэхэд хэн зогсоогоороо үлдэж чадах билээ? Учир нь тэрбээр “хайлагчийн гал лугаа адил, мөн хувцас угаагчийн саван лугаа адил болой.

3 Мөн тэрбээр мөнгө хайлагч мөн цэвэршүүлэгч лугаа адил суух болно, мөн тэд Их Эзэнд зөв шударга байдалд өргөл “өргөж болохын тулд тэр Левийн “хөвгүүдийг цэвэршүүлнэ, мөн тэднийг алт болоод мөнгө лугаа адил ангижруулан цэвэршүүлэх болно болой.

4 Тэгээд Иудейн мөн Иерусалимын өргөл Их Эзэнд, эртний өдрүүдийнх шиг, мөн урьдын жилүүдийнх шиг таалагдах болно.

5 Мөн би та нарын дэргэд шүүхээр ирэх болно; мөн би илбэ шидтэнгүүдийн эсрэг,

14a Лук 24:44–46.

24 1a С ба Г 45:9.

2a 3 Ниф. 25:1.

б Зех. 13:9;

С ба Г 128:24.

су Дэлхий—
Дэлхийн
цэвэршилт; Есүс
Христийн Хоёр
дахь Ирэлт.

3a С ба Г 13:1.

б Дэд хууль 10:8;

С ба Г 84:31–34.

мөн садар самууныг үйлдэгчдийн эсрэг, мөн хуурамч ам тангараг тавигчдын эсрэг, мөн хөлслөгчдийнхөө цалин хөлсөөр нь дарлан хавчдаг, бэлэвсэн мөн “эцэггүйг дарлан, мөн харь нэгэнд туслахаас татгалзан, мөн надаас үл эмээдэг тэдний эсрэг би шуурхай гэрч байх болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг.

6 Учир нь би бол Их Эзэн, би өөрчлөгддөггүй; тиймийн тул Иаковын хөвгүүд та нар шатаагдаагүй.

7 Бүр эцэг өвгөдийнхөө өдрүүдээс та нар ёслолуудаас минь “зайцан явсан, мөн тэдгээрийг дагаагүй. Надад эргэж ир мөн би та нарт ^бэргэж очих болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг. Гэвч: Бид хэрхэн эргэж очих билээ? хэмээн та нар хэлдэг.

8 Хүмүүн Бурханыг дээрэмдэх үү? Гэсэн ч та нар намайг дээрэмдсэн билээ. Гэвч: Бид хэрхэн таныг дээрэмдэв? хэмээн та нар хэлдэг. “Аравны нэг болон ^бөргөлүүдээр.

9 Та нар зүхлээр зүхэгдсэн, учир нь та нар, бүр энэ бүхэл үндэстэн намайг дээрэмдсэн билээ.

10 Өргөөнд минь хүнс байж болохын тулд та нар “аравны нэг болох бүхнийг агуулахад авчирцгаа; мөн эдүгээ, үүнийг хүлээн авах хангалттай зай байхгүй болтол би

тэнгэрийн цонхнуудыг нээж, мөн та нарын дээр ^бадислаглыг цутгах эсэхийг үүгээр намайг сорь хэмээн Түмний Их Эзэн хэллээ.

11 Мөн би та нарын тусын тулд залгигчийг ээмлэх болно, мөн тэрбээр газар дахь үр жимсийг тань устгахгүй; бас мөчир чинь ч цагаас өмнө жимсээ талбайд унагахгүй хэмээн Түмний Их Эзэн хэлдэг.

12 Мөн бүх үндэстэн та нарыг адислагдсан хэмээн дуудах болно, учир нь та нар таатай сайхан нутаг байх болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг.

13 Та нарын үгс миний эсрэг хүчтэй байсан хэмээн Их Эзэн хэлдэг. Гэсэн ч та нар хэлдэг: Таны эсрэг бид юу ярьсан билээ?

14 Та нар хэлдэг: Бурханд үйлчлэх нь хоосон, мөн түүний ёслолуудыг дагалаа гээд мөн бид Түмний Их Эзэний өмнө гашуудал дүүрэн алхсан гээд ямар ашиг байх билээ?

15 Мөн эдүгээ бид бардам тэднийг аз жаргалтай хэмээдэг; тийм ээ, тэд ёс бусыг үйлддэг, тэд дэгжсэн; тийм ээ, Бурханыг өдөөх тэд бүр чөлөөлөгдсөн байдаг.

16 Тэгээд Их Эзэнээс эмээх тэд ойр ойрхон нэг нэгэнтэйгээ “ярьж мөн Их Эзэн анхаарч мөн сонссон бөлгөө;

5a Иаков 1:27.
7a су Урвалт.
б Хил. 13:11;
3 Ниф. 10:6;
Моро. 9:22.

8a су Аравны нэг
төлөх, Аравны нэг.
б су Өргөл.
10a С ба Г 64:23; 119:1–7.
б су Адислах,

Адислагдах,
Адислал.
16a Моро. 6:5.

мөн Их Эзэнээс эмээх мөн түүний нэрийг бишрэн бодох тэдний төлөө дурсамжийн ^бном түүний өмнө бичигдсэн бөлгөө.

17 Мөн би үнэт чулуунуудаа “цуглуулах тэр өдөр тэд минийх байх болно; мөн өөрт нь үйлчлэх хүүгээ энэрэх хүмүүний адил би тэднийг энэрэн хэлтрүүлэх болно гэж Түмний Их Эзэн хэлдэг.

18 Тэгээд та нар эргэж ирэн мөн зөв шударгыг үйлдэгчид мөн ёс бусыг үйлдэгчдийн хоорондох, Бурханд үйлчилдэг мөн түүнд үйлчилдэггүй тэдний хоорондох “ялгааг олж харах болно.

БҮЛЭГ 25

Хоёр дахь Ирэлтэнд, бардам хийгээд ёс бус тэд талбайд хаягдсан сүрэл лугаа адил шатаагдах болно—Тэр агуу хийгээд аймшигт өдрийн өмнө Елиа эргэж ирэх болно—Малахи 4 дүгээр бүлэгтэй харьцуул. Ойролцоогоор мэ 34 он.

Учир нь болгоогтун, зууханд “шатах лугаа адил тийм өдөр ирнэ; мөн ^ббардамнагчид, бүгд, тийм ээ, мөн ёс бусыг үйлдэх тэд бүгд, талбайд

хаягдсан сүрэл лугаа адил байх болно; мөн ирэх тэр өдөр тэднийг шатаах болно, энэ нь тэдгээрийн үндсийг ч бас мөчрийг нь ч эс үлдээх болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг.

2 Гэвч нэрнээс минь эмээх та нарт, “Зөв Шударгын Хүү жигүүртээ эдгээх чадлыг эзэмдэн босох болно; мөн та нар одож мөн пүнзэнд байгаа ^бтугалууд лугаа адил ^өөсөх болно.

3 Мөн та нар ёс бусыг үйлдэгчдийг доош “дэвслэх болно; учир нь би үүнийг үйлдэх тэр өдөр тэд хөлийн чинь улан доорх нурам чандруу байх болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг.

4 Бүх Израилын төлөө “Хорebt дүрмүүд болоод тогтоолуудын хамт түүнд миний зарлиг болгосон, миний үйлчлэгч Мосегийн хуулийг санагтун, та нар.

5 Болгоогтун, Их Эзэний “агуу хийгээд аймшигт өдөр ирэхийн өмнө би та нарт бошиглогч ^бЕлиаг илгээх болно;

6 Мөн би ирж мөн дэлхийг зүхлээр цохихгүйн тулд тэрбээр эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүдэд нь, мөн

16б С ба Г 85:9; Моце 6:5.
су Дурсамжийн ном.

17а С ба Г 101:3.

18а су Ялган таних
бэлэг.

25 1а Иса. 24:6;

1 Ниф. 22:15;

3 Ниф. 24:2;

С ба Г 29:9; 64:23–24;
133:64;

ИС—Т 1:37.

су Дэлхий—

Дэлхийн
цэвэршилт.

б 2 Ниф. 20:33.

су Бардамнал.

2а Ифер 9:22.

б Амос 6:4;

1 Ниф. 22:24.

в С ба Г 45:58.

3а 3 Ниф. 21:12.

4а Ег. 3:1–6.

5а су Есүс Христийн
Хоёр дахь Ирэлт.

б Хаад. дэд 2:1–2;

С ба Г 2:1; 110:13–16;
128:17–18.

су Елиа; Нас
барагсдын аврал;
Лацдах, Лацдалт.

хүүхдүүдийнх нь зүрх сэтгэлийг эцгүүдэд нь “эргүүлэх болно.

БҮЛЭГ 26

Эхлэлээс төгсгөл хүртэлх бүх зүйлийг Есүс тайлбарлав—Нялхас мөн хүүхдүүд бичигдэх аргагүй гайхамшигт зүйлийг хэлэв—Христийн Сүм дэх тэд өөрсдийн дунд бүх зүйлийг нийтээр эзэмшив. Ойролцоогоор мэ 34 он.

Мөн эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр зүйлийг хэлээд тэрбээр цугласан олонд тэдгээрийг тайлбарлав; мөн тэрбээр тэдэнд, агуу их бас бяцхан аль алиныг нь бүх зүйлийг тайлбарласан болой.

2 Мөн тэрбээр хэлэв: Та нарт өөрсдөд тань байгаагүй “эдгээр судруудыг би та нарт өгөхийг Эцэг надад зарлиг болгосон бөлгөө; учир нь тэдгээр нь ирээдүйн үеүдэд өгөгдөх болно гэсэн нь түүний мэргэн ухаан байв.

3 Мөн тэрбээр бүх зүйлийг тайлбарлав, бүр эхлэлээс тэрбээр “алдар суундаа ирэх тэр цагийг хүртэл буюу—тийм ээ, бүр газрын гадаргуу дээр ирэх тэр бүх зүйлийг, бүр

“бичил хэсгүүд ч гал халуунд хайлах, мөн газар дэлхий хуйлмал бичиг лугаа адил “хуйлагдаж, мөн тэнгэр хийгээд газар үгүй болох хүртэл; 4 Мөн бүр бүх хүмүүс, мөн бүх ястан, мөн бүх үндэстэн мөн хэлтнүүд Бурханы өмнө өөрсдийн үйлүүдээр, тэдгээр нь сайн эсвээс хилэнцэт эсэхээр шүүгдэхээр “зогсох тэрхүү “агуу хийгээд эцсийн өдөр хүртэл—

5 Хэрэв тэдгээр нь сайн аваас, үүрдийн амьдралын “амилуулалтанд; мөн хэрэв тэдгээр нь хилэнцэт бөгөөс, ялын амилуулалтанд байна; эн зэрэгцээ байх тэр, нэг нь нэг гарт мөн нөгөө нь нөгөө гар талд, дэлхийн эхлэлээс “өмнө байсан Христ дэх нигүүлслийн, мөн “шударга ёсны, мөн ариун чанарын дагуу байх бөлгөө.

6 Мөн эдүгээ уг хүмүүст Есүсийн үнэхээр сургасан тэр зүйлүүдийн бүр “зууны нэг хэсэг нь ч энэ номонд бичигдэх аргагүй;

7 Гэвч болгоогтун Нифайн “ялтсууд уг хүмүүст түүний заасан зүйлүүдийн өөр хэсгийг агуулдаг болой.

8 Мөн эдгээр зүйлийг, уг

6а С ба Г 2:2.
26 2а өх 3 Ниф. Бүлэг
24 ба 25-д иш
татагдсан
Малахийн бүлэг 3
ба 4.
3а су Есүс Христ—
Есүс Христийн
алдар суу.
б Амос 9:13;
2 Петр 3:10, 12;

Морм. 9:2.
су Дэлхий—
Дэлхийн
цэвэршилт;
Дэлхий—Дэлхийн
төгсгөл.
в Морм. 5:23.
4а Мозая 16:10–11.
су Эцсийн шүүлт.
б Хил. 12:25;
3 Ниф. 28:31.

5а Дан. 12:2;
Иохан 5:29.
б Ифер 3:14.
су Есүс Христ—
Христийн мөнх бус
байдлын өмнөх
амьдрал.
в су Шударга ёс.
6а Иохан 21:25;
3 Ниф. 5:8.
7а су Ялтсууд.

хүмүүст түүний заасан зүйлүүдийн багахан хэсгийг би бичиглэсэн; мөн тэдгээр нь Есүсийн ярьсан үгсийн дагуу, энэ хүмүүст “харийнханаас захин авчрагдаж болно гэсэн зорилготойгоор тэдгээрийг бичиглэсэн бөлгөө би.

9 Мөн эхэлж авах нь зайлшгүй болох үүнийг итгэл нь соригдохын тулд тэд хүлээн аваад, мөн хэрэв тэд эдгээр зүйлд итгэх аваас, тэгвэл “агуу зүйлүүд тэдэнд үзүүлэгдэх болно.

10 Мөн хэрэв эдгээр зүйлүүдэд тэд итгэхгүй аваас, тэгвэл тэднийг буруутгах буруушаалт болон илүү агуу зүйлүүд тэднээс “далдлагдах болно.

11 Болгоогтун, Нифайн ялтсууд дээр сийлбэрлэгдсэн бүгдийг би бичих гэж байв, гэвч Их Эзэн үүнийг хориглож, хэлсэн нь: Би өөрийн хүмүүсийн итгэлийг “сорих болно.

12 Тиймийн тул би, Мормон, Их Эзэнээс надад зарлиг болгогдсон зүйлийг бичсэн бөлгөө. Мөн эдүгээ би, Мормон, үгсээ төгсгөл болгон, мөн надад зарлиг болгогдсон зүйлийг бичихээ үргэлжлүүлье.

13 Тиймийн тул, Их Эзэн гурван өдрийн турш уг хүмүүст үнэхээр заасныг та нар болгоогоосой хэмээнэ би; мөн тэгснийхээ дараа тэрбээр

өөрийгөө тэдэнд ойр ойрхон “үзүүлсэн, мөн ойр ойрхон ^бталх хувааж, мөн үүнийг адисалж, мөн үүнийг тэдэнд өгсөн болой.

14 Мөнхүү улиран тохиох дор тухайлан яригдсан цугласан олны “хүүхдүүдэд тэрбээр зааж мөн тохинуулж, мөн тэрбээр тэдний хэлийг ^бхурц болгон, мөн тэд агуу хийгээд гайхамшигт зүйлийг, бүр түүний хүмүүст илчилснээс ч илүү агуу эцгүүддээ ярьсан ажгуу; мөн тэд ярьж чадахын тулд тэдний хэлийг тэрбээр хурцалсан бөлгөө.

15 Мөнхүү улиран тохиох дор тэр тэнгэрт дээшлэн одсоныхоо — хоёр дахь удаагаа тэдэнд өөрийгөө үзүүлж, мөн тэдний өвдсөнийг мөн доголонг “эдгээж, мөн тэдний хараагүйнх нь нүдийг нээж, мөн дүлийнх нь чихний бөглөөсийг гаргаж, мөн бүр төрөл бүрийн эдгээлтийг тэдний дунд үйлдэж, мөн хүмүүнийг нас барагсдын дундаас босгож, мөн тэдэнд өөрийн хүчийг үзүүлснийхээ дараа Эцэгт очив, мөн Эцэгт дээшлэн одсоныхоо дараа болой —

16 Болгоогтун, улиран тохиох дор маргааш нь олон түмэн нэгдэн цугларцгааж, мөн тэд эдгээр хүүхдүүдийг харж мөн сонсоцгоов; тийм ээ, бүр “нялхас ч амаа нээж мөн гайхамшигт зүйлийг хэлэв;

8а 3 Ниф. 21:5–6.

9а Ифер 4:4–10.

10а Алма 12:9–11.

11а Ифер 12:6.

13а Иохан 21:14.

б 3 Ниф. 20:3–9.

су Ариун ёслол.

14а 3 Ниф. 17:11–12.

б Алма 32:23;

3 Ниф. 26:16.

15а 3 Ниф. 17:9.

су Эдгээх, Эдгэрэх;

Гайхамшиг.

16а Мат. 11:25.

мөн тэдний хэлсэн зүйлийг ямар ч хүмүүн тэдгээрийг бичих нь хориглогдов.

17 Мөнхүү улиран тохиох дор Есүсийн сонгосон “шавь нар тэр цагаас ирсэн болгонд ^ббаптисм хүртээж мөн тэдэнд зааж эхлэв; мөн Есүсийн нэрээр баптисм хүртсэн болгон нь Ариун Сүнсээр дүүргэгдэв.

18 Мөн тэдний олон нь бичигдэх нь “зөвшөөрөгдөөгүй, үгээр хэлшгүй зүйлийг үзэж мөн сонсов.

19 Мөн тэд нэг нэгэндээ зааж мөн тохинуулсан болой; мөн тэд “бүх зүйлийг ^бдундаа нийтээр эзэмшиж, хүн бүр нэг нэгэндээ шударгаар хандаж байв.

20 Мөнхүү улиран тохиох дор тэд яг Есүсийн тэдэнд зарлиг болгосончлон бүх зүйлийг ёсчлон хийжээ.

21 Мөн Есүсийн нэрээр баптисм хүртсэн тэд Христийн “сүм хэмээн нэрлэгдэв.

БҮЛЭГ 27

Сүмийг өөрийнх нь нэрээр нэрлэхийг Есүс тэдэнд зарлиг болов — Түүний үүрэг, зорилго хийгээд цагаатгагч золиослол түүний сайн мэдээг бүрдүүлдэг — Тэд Ариун Сүнсээр ариусгагдаж болохын тулд хүмүүс наманчлахаар

мөн баптисм хүртэхээр зарлиг болгогдов — Тэд бүр яг Есүс шиг байх учиртай. Ойролцоогоор мэ 34–35 он.

Мөнхүү улиран тохиох дор Есүсийн шавь нар аялж мөн өөрсдийн сонссон мөн үзсэн зүйлийг номлож, мөн Есүсийн нэрээр баптисм хүртээж байх үед, улиран тохиох дор шавь нар нь нэгдэн цугларцгааж мөн хүчирхэг залбирал мөн “мацаг барилтад ^бнэгдэв.

2 Мөн Есүс өөрийгөө дахин тэдэнд “үзүүлэв, учир нь тэд Эцэгт хандан түүний нэрээр залбирч байсан ажээ; мөн Есүс ирж мөн тэдний дунд зогсоод, мөн тэдэнд хэлэв: Та нарт намайг юу өгөөсэй хэмээн та нар хүснэв?

3 Мөн тэд түүнд хэлэв: Их Эзэн, энэ сүмийг ямар нэрээр нэрлэхийг бидэнд хэлээсэй хэмээн бид танаас хүсч байна; учир нь энэ хэргийн талаар хүмүүсийн дунд арцалдаан байна.

4 Мөн Их Эзэн тэдэнд хэлэв: Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, хүмүүс яагаад энэ хэргийн учир бувтналдан мөн арцалдах болов?

5 Миний нэр болох, Христийн “нэрийг та нар өөрсдийн дээр авах ёстой хэмээсэн, судруудыг тэд уншаагүй гэж үү?

17a 3 Ниф. 19:4–13.

б 4 Ниф. 1:1.

18a 3 Ниф. 26:11.

19a 4 Ниф. 1:3.

б су Өргөл болгох,
Өргөлийн хууль.

21a Мозая 18:17.

су Есүс Христийн

Сүм.

27 1a С ба Г 29:6.

б Алма 6:6.

су Мацаг барих,
Мацаг барилт.

2a 3 Ниф. 26:13.

су Есүс Христ—

Христийн мөнх бус

амьдралын дараах ирэлт.

5a су Есүс Христ—
Өөрсөд дээрээ Есүс Христийн нэрийг авах.

Учир нь энэ нэрээр та нар эцсийн өдөр дуудагдах болно; 6 Мөн өөрийн дээр миний нэрийг авсан, мөн эцсээ хүртэл “тэвчих хэн боловч, чухамхүү тэр нь эцсийн өдөр аврагдах болно.

7 Тиймийн тул, та нар юуг ч үйлдсэн, үүнийгээ миний нэрээр үйлдэх болно; тиймийн тул та нар сүмийг миний нэрээр нэрлэх болно; мөн тэрбээр миний тусын тулд сүмийг адислахын тулд та нар миний нэрээр Эцэгт хандах болно.

8 Мөн энэ нь миний нэрээр нэрлэгдэхгүй аваас яахан “миний ^бсүм байх билээ? Учир нь хэрэв сүм Мосегийн нэрээр нэрлэгдсэн байвал энэ нь Мосегийн сүм; эсвэл хэрэв энэ нь хүмүүний нэрээр нэрлэгдсэн байвал уг сүм нь хүмүүний сүм байна; харин энэ нь миний нэрээр нэрлэгдвэл, хэрэв тэд миний сайн мэдээн дээр тулгуурлах аваас, тэгвэл энэ нь миний сүм мөн.

9 Үнэнээр би та нарт хэлнэ, та нар миний сайн мэдээн дээр тулгуурласан; тиймийн тул та нар нэрлэсэн бүхнээ миний нэрээр нэрлэх болно; тиймийн тул хэрэв та нар уг сүмийн төлөө Эцэгт хандан гуйж, хэрэв энэ нь миний нэрээр аваас Эцэг та нарыг сонсох болно;

10 Мөн хэрэв уг сүм нь миний сайн мэдээн дээр тулгуурласан аваас тэгвэл Эцэг үүний дотор өөрийнхөө ажлуудыг үзүүлэх болно.

11 Гэвч хэрэв энэ нь миний сайн мэдээн дээр тулгуурлаагүй, мөн хүмүүний ажлууд дээр, эсвээс чөтгөрийн ажлууд дээр тулгуурласан аваас, үнэнээр би та нарт хэлнэ, тэд өөрсдийн ажлууддаа түр зуур л баясна, мөн төдөлгүй төгсгөл ирэхэд, мөн тэд “тас цавчигдан мөн эргэж гарах аргагүй галд хаягдах болно.

12 Учир нь үйлүүд нь тэднийг “дагадаг, өөрөөр хэлбэл тэдний тас цавчигдах нь тэдний үйлүүдийн улмаас болой; тиймийн тул та нарт миний хэлсэн зүйлийг санагтун.

13 Болгоогтун би өөрийн “сайн мэдээг та нарт өгсөн, мөн энэ бол та нарт миний өгсөн тэр сайн мэдээ— Эцэг минь намайг илгээсний учир би Эцэгийнхээ ^бтааллыг гүйцэлдүүлэхээр дэлхийд ирсэн билээ.

14 Мөн би “загалмай дээр өргөгдөж болохын тулд, би загалмай дээр өргөгдсөний дараа, би бүх хүмүүнийг өөртөө ^бтатаж болохын тулд, би хүмүүнээр өргөгдсөний адилаар хүмүүн миний өмнө зогсож, өөрсдийн үйлүүдээр тэд сайн эсвэл хилэнцэт байх эсэхээрээ “шүүгдэхээр Эцэ-

6a 3 Ниф. 15:9.

8a С ба Г 115:4.

б су Есүс Христ—
Сүмийн Тэргүүн.

11a Алма 5:52.

12a Илч. 14:13;

С ба Г 59:2.

13a С ба Г 76:40–42.

су Сайн Мэдээ.

б Иохан 6:38–39.

14a 1 Ниф. 11:32–33;

Моце 7:55.

б Иохан 6:44;

2 Ниф. 9:5;

С ба Г 27:18.

в су Есүс Христ—
Шүүгч.

гээр өргөгдөхийн тулд Эцэг минь намайг илгээсэн бөлгөө;

15 Мөн энэ шалтгааны учир би “өргөгдөв; тиймийн тул тэд өөрсдийн үйлүүдийн дагуу шүүгдэж болохын тулд Эцэгийн хүчний дагуу би бүх хүмүүнийг өөртөө татах болно.

16 Мөнхүү улиран тохиох дор, “наманчилж мөн миний нэрэнд ^ббаптисм хүртэх хэн боловч дүүргэгдэх болно; мөн хэрэв тэр эцсээ хүртэл “тэвчих аваас, болгоогтун, би дэлхийг шүүхээр зогсох тэр өдөр Эцэгийнхээ өмнө би түүний гэмгүйг үнэлэх болно.

17 Мөн эцсээ хүртэл үл тэвчсэн тэрбээр, чухамхүү тэр нь түүнчлэн тас цавчигдаж мөн тэд тэндээс дахин эргэж ирэх аргагүй галд хаягдах тэр нь мөн, учир юун гэвэл Эцэгийн “шударга ёсных юм.

18 Мөн хүмүүний үрсэд түүний өгсөн тэр үг нь энэ юм. Мөн энэхүү шалтгааны учир тэрээр өгсөн үгсээ гүйцэлдүүлнэ, мөн тэрбээр худал хэлдэггүй, харин өөрийн бүх үгсийг гүйцэлдүүлдэг.

19 Мөн “ямар ч цэвэр бус зүйл түүний хаант улсад орж чадахгүй; тиймийн тул өөрсдийн итгэл, мөн өөрсдийн бүх нүглийн наманчлал, мөн төгсгөл хүртэлх өөрсдийнх

нь үнэнч шударга байдлын учир миний цусанд өөрсдийн өмсгөлийг ^вугаасан тэднээс бусад юу ч түүний “амралтад орохгүй.

20 Эдүгээ уг зарлиг нь энэ болой: Ариун Сүнсний хүлээн авалтаар та нар “ариусгагдаж болохын тулд, эцсийн өдөр та нар миний өмнө ^бтолбогүйгээр зогсож болохын тулд “наманчлагтун, мөн надад ирэгтүн мөн миний нэрээр ‘баптисм хүртэгтүн, газар дэлхийн хязгаарууд та нар бүгд.

21 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, энэ бол миний сайн мэдээ; мөн миний сүмд хийх ёстой зүйлүүдээ та нар мэднэ; учир нь миний хийхийг та нарын харсан тэр ажлуудыг та нар түүнчлэн хийх болно; учир нь миний хийснийг та нар харсан, бүр түүнийг та нар хийх болно;

22 Тиймийн тул, хэрэв та нар эдгээр зүйлийг хийх аваас та нар адислагдана, учир нь та нар эцсийн өдөр өргөгдөх болно.

23 “Хориглогдсон тэдгээрээс бусад, өөрсдийн үзсэн мөн дуулсан тэр зүйлүүдээ бичигтүн.

24 Бүр байсан тэрний бичигдсэн лугаа адил, энэ хүмүүсийн байх тэр ажлуудыг бичигтүн.

15a су Цагаатгах,
Цагаатгал.
16a су Наманчлах,
Наманчлал.
б су Баптисм,
Баптисм хүртээх.
в 1 Ниф. 13:37.
су Тэвчих.

17a су Шударга ёс.
19a Алма 11:37.
б Илч. 1:5; 7:14;
Алма 5:21, 27;
13:11–13.
в С ба Г 84:24.
су Амрах.
20a су Ариусгал.

б С ба Г 4:2.
в Ифер 4:18.
г су Баптисм,
Баптисм хүртээх
нь—чухал
шаардлага.
23a 3 Ниф. 26:16.

25 Учир нь болгоогтун, тэдний “ажлууд тэдгээрээр хүмүүнд мэдэгдэхийн учир бичигдсэн байгаа, мөн бичигдэх тэр номнуудаас энэ хүмүүс ^бшүүгдэх болно.

26 Мөн болгоогтун, бүх зүйл Эцэгээр “бичигдсэн юм; тиймийн тул бичигдэх тэрхүү номнуудаас дэлхий шүүгдэх болно.

27 Мөн шударга байх, та нарт миний өгөх шүүлтийн дагуу “та нар энэ хүмүүсийн шүүгчид байх болно хэмээн та нарыг мэдээсэй хэмээнэ. Тиймийн тул, та нар ямархуу ^бмаягийн хүмүүс байвал зохих билээ? Үнэнээр би та нарт хэлье, бүр ^вминий адил буюу.

28 Мөн эдүгээ би Эцэгтээ “очно. Мөн үнэнээр би та нарт хэлье, та нар Эцэгээс миний нэрээр гуйсан юу боловч, тэр зүйл та нарт өгөгдөх болно.

29 Тиймийн тул “гуй, тэгвэл та нар хүлээн авна, тогш, тэгвэл энэ нь та нарт нээгдэх болно; учир нь гуйсан тэр нь хүлээн авна; мөн тогших түүнд, энэ нь нээгдэх болно.

30 Мөн эдүгээ, болгоогтун, та нарын, мөн түүнчлэн энэ үеийнхний учир баясал минь агуу байна, бүр дүүртлээ; тийм ээ, мөн түүнчлэн бүх ариун тэнгэр элчүүд, та

нарын мөн энэ үеийнхний учир бүр Эцэг ч баясана; учир нь тэдний “хэн нь ч төөрөлдөөгүй бөлгөө.

31 Болгоогтун, та нарыг ойлгоосой хэмээнэ би; учир нь тэд гэж “энэ үеийн ^бэдүгээ амьд байгаа тэднийг би хэлсэн билээ; мөн тэдний хэн нь ч алдагдсангүй; мөн тэдний улмаас би ^вбаяслын дүүрнийг амсах бөлгөө.

32 Гэвч болгоогтун, энэ үеэс “дөрөв дэх үеийнхний учир би харамсана, учир нь тэд бүр мөхлийн хүү лугаа адил боолчлолд түүгээр удирдагдан одох бөлгөө; учир нь мөнгөний төлөө мөн алтны төлөө, мөн ^вцагаан эрвээхийд идэгдэх мөн хулгайч нар эвдэж ороод мөн хулгайлж болох зүйлийн төлөө тэд намайг худалдах болно. Мөн тэр өдөр бүх ажлуудыг нь өөрсдийнх нь тэргүүнүүд дээр эргүүлсэн би тэдэнд зочлох болно.

33 Мөнхүү улиран тохиох дор эдгээр үгсээ Есүс дуусгаад тэрээр шавь нартаа хэлэв: “давчуу хаалгаар орогтун та нар; учир юун гэвэл аминд удирдах хаалга нь давчуу, мөн зам нь нарийн, мөн үүнийг олох нь цөөн бөлгөө; харин үхэлд удирдах хаалга

25a 1 Ниф. 15:32–33.

б 2 Ниф. 33:10–15;
Мор. үгс 1:11.

26a 3 Ниф. 24:16.
су Амьдралын ном.

27a 1 Ниф. 12:9–10;
Морм. 3:19.

б су Есүс Христ—
Есүс Христийн

үлгэр жишээ.

в Мат. 5:48;
3 Ниф. 12:48.

28a Иохан 20:17.

29a Мат. 7:7;

3 Ниф. 14:7.

30a Иохан 17:12.

31a 3 Ниф. 28:23.

б 3 Ниф. 9:11–13; 10:12.

в су Баяр баясгалан.

32a 2 Ниф. 26:9–10;
Алма 45:10, 12.

б Мат. 6:19–21;

3 Ниф. 13:19–21.

33a Мат. 7:13–14;

3 Ниф. 14:13–14;

С ба Г 22:1–4.

өргөн, мөн зам нь дардан, мөн түүгээр замнах нь олон болой, ямар ч хүмүүн ажиллаж үл чадах тэр шөнийг ирэх хүртэл бөлгөө.

БҮЛЭГ 28

Арванхоёрын ес нь наснаас халихдаа Христийн хаант улсад өвийг хүсч мөн амлагдав—Гурван нифай үндэстэн Есүсийн дахин ирэх хүртэл газар дэлхий дээр үлдэхийг хүсэж мөн үхлийг давах хүч өгөгдөв—Тэд хувиргагдаж мөн хэлэх нь хууль бус зүйлийг харсан буюу, мөн тэд эдүгээ хүмүүний дунд тохинуулж буй. Ойролцоогоор мэ 34–35 он.

Мөнхүү улиран тохиох дор Есүс эдгээр үгийг хэлээд, тэрээр шавь нартаа, нэг нэгээр нь ярьж, тэдэнд хэлсэн нь: намайг Эцэгтээ очсоны дараа, та нар надаас юу хүсэх вэ?

2 Мөн тэд бүгд ярьж, гурваас бусад нь хэлэв: Бид хүний насыг насалсны дараа, бид таны хаант улсад танд хурдан очиж болно хэмээн биднийг таны дуудсан тохинуулал маань төгсөж болохыг бид хүсч байна.

3 Мөн тэрээр тэдэнд хэлэв: Та нар энэ зүйлийг надаас хүссэн учраас адислагдсан болой та нар; тиймийн тул, та нар даланхоёр настай болсныхоо дараа хаант улсад минь

надад ирэх болно; мөн надтай хамт та нар “амар амгаланг олох болно.

4 Мөн тэрээр тэдэнд ярьсныхаа дараа, тэрээр сайхь гурвын зүг эргэж, мөн тэдэнд хэлэв: Намайг Эцэгтээ очоод, та нарын төлөө намайг юу хийхийг та нар хүсч байна?

5 Мөн тэд зүрх сэтгэлдээ харамсав, учир нь хүссэн зүйлээ түүнд ярьж тэд зүрхэлсэнгүй.

6 Мөн тэрээр тэдэнд хэлэв: Болгоогтун, би та нарын бодлуудыг “мэднэ, мөн намайг иудейчүүдээр өргөгдөхөөс өмнө, миний тохинуулалд надтай хамт байсан, миний хайрт ⁶Иохан надаас хүссэн тэр зүйлийг та нар хүсч буй.

7 Тиймийн тул, та нар илүүтэй адислагдсан болой, учир нь та нар хэзээ ч “үхлийг ⁶амсахгүй; харин бүр намайг тэнгэрийн “хүчтэйгээр алдар суундаа ирэх үед, Эцэгийн тааллын дагуу бүх зүйл гүйцэлдэх хүртэл та нар хүмүүний үрсэд Эцэгийн бүх үйлүүдийг болгоохоор амьдрах болно.

8 Мөн та нар үхлийн шаналлыг хэзээ ч үзэхгүй; харин намайг алдар суундаа ирэх үед та нар нүд ирмэхийн “зуур зуурдын байдлаас ⁶үхэшгүй байдалд өөрчлөгдөх болно; мөн тэгээд та нар миний Эцэгийн хаант улсад адислагдах болно.

28 3а су Амрах.

6а Амос 4:13;

Алма 18:32.

б Иохан 21:21–23;

С ба Г 7:1–4.

7а су Зөөгдсөн

хүмүүн биес.

б 4 Ниф. 1:14;

Морм. 8:10–11;

Ифер 12:17.

в 3 Ниф. 20:22.

8а 3 Ниф. 28:36–40.

су Мөнх бус, Мөнх бус байдал.

б су Мөнх бус, Мөнх бус байдал.

9 Мөн тэрчлэн, бие махбодид орших үед та нарт зовуурь үгүй байх болно, бас дэлхийн нүглүүдийн төлөө бус аваас харамсал ч үгүй байх бөлгөө; мөн та нарын надаас хүссэн тэр зүйлийн учир би энэ бүгдийг хийх болно, учир нь дэлхий оршин тогтнож байхад, хүмүүний бодгалийг надад “авчирч болох болоосой хэмээн та нар хүссэн билээ.

10 Мөн энэ шалтгааны улмаас та нарт “баяслын бүрэн дүүрэн нь байх болно; мөн та нар миний Эцэгийн хаант улсад суух болно; тийм ээ, баясал тань дүүрэн байх болно, бүр Эцэг надад баяслын бүрэн дүүрнийг өгсөн лугаа адил бөлгөө; мөн та нар бүр миний адил байх болно, мөн би бол бүр Эцэгийн адил, мөн Эцэг бид хоёр ⁶нэг билээ;

11 Мөн “Ариун Сүнс Эцэгийн болон миний тухай гэрчилдэг; мөн Эцэг хүмүүний үрсэд миний учир, Ариун Сүнс өгдөг.

12 Мөнхүү улиран тохиох дор Есүс эдгээр үгийг яриад, тэрээр үлдэх гурваас бусдад нэг бүрчлэн хуруугаараа хүрч, мөн тэгээд тэрбээр одов.

13 Мөн болгоогтун, тэнгэр нээгдэж, мөн тэд тэнгэрт “шүүрэгдэж, мөн өгүүлшгүй зүйлийг харж бас сонсов.

14 Мөн тэдний хэлэх нь тэдэнд “хориглогдов; бас тэд үзсэн мөн сонссон зүйлүү-

дээ ярьж чадах хүч тэдэнд өгөгдсөнгүй;

15 Мөн тэд бие махбодид эсвээс бие махбодийн гадна байсан эсэхээ тэд хэлж чадсангүй; учир нь энэ бол тэдэнд өөрсдийнх нь “хувиралт мэт санагдаж, тэд Бурханы зүйлийг болгоож чадахын тулд тэд маханбодийн энэ биеэсээ үхэшгүй байдалд өөрчлөгдөв.

16 Гэвч улиран тохиох дор тэд газрын гадаргуу дээр дахин тохинуулав; гэсэн хэдий ч тэнгэрт тэдэнд өгөгдсөн тэр зарлигийн учир, тэд сонссон мөн үзсэн зүйлүүдийнхээ тухайд тохинуулсангүй.

17 Мөн эдүгээ, тэдний хувиргалтын өдрөөс хойш, тэд зуурдын эсвээс үхэшгүй байсан эсэхийг би мэдэх нь үгүй;

18 Харин өгөгдсөн тэрхүү цэдгийн дагуу, би энэ зэргийг мэднэ — тэд уг нутгийн гадаргуу дээр урагш явж, мөн бүх хүмүүст тохинуулан, номлолд нь итгэсэн болгоныг сүмд нэгтгэв; тэдэнд баптисм хүртээж, мөн баптисм хүртсэн болгон нь Ариун Сүнс хүлээн авсан болой.

19 Мөн тэд сүмд харьяалагдаагүй тэднээр шоронд хаягдав. Мөн “шоронгууд ч, тэдгээр нь хоёр хуваагдан цуурсаны учир тэднийг барьж хүч хүрсэнгүй.

20 Мөн тэд газар дор хаягдав; гэвч тэд Бурханы үгээр уг

9а Филип. 1:23–24;
С ба Г 7:5–6.
10а С ба Г 84:36–38.
б Иохан 17:20–23.

11а 2 Ниф. 31:17–21;
3 Ниф. 11:32.
13а 2 Кор. 12:2–4.
14а С ба Г 76:114–116.

15а Моисе 1:11.
су Зөөгдөлт.
19а Үйлс 16:26;
Алма 14:26–28.

газрыг цохиж, үүний хэрээр түүний “хүчээр тэд газрын гүнээс чөлөөлөгдөв; мөн тиймийн тул тэднийг барьж байх тийм нүхнүүдийг тэд ухаж чадсангүй.

21 Мөн тэд “зууханд гурван-таа хаягдаж тэгээд гэмтэл авсангүй.

22 Мөн тэд зэрлэг араатны “үүрэнд хоёр удаа хаягдав; мөн болгоогтун тэд хөхүүл хүүхэд хургатай лугаа адил мэт тэр араатнуудтай тоглож, мөн гэмтэл авсангүй.

23 Мөнхүү улиран тохиох дор тэд тийн Нифайн бүх хүмүүсийн дунд явж, мөн Христийн “сайн мэдээг уг нутгийн гадаргуу дээрх бүх хүмүүст номлов; мөн тэд Их Эзэнд хөрвүүлэгдэж, мөн Христийн сүмд нэгтгэгдэв, мөн тийн ⁶тэр үеийн хүмүүс, Есүсийн үгийн дагуу адислагдав.

24 Мөн эдүгээ, би, Мормон, эдгээр зүйлийн талаарх яриа-гаа хэсэг зуур төгсгөл болгоё.

25 Болгоогтун, би үхлийг хэзээ ч амсахгүй тэдний “нэрсийг бичих гэж байв, гэвч Их Эзэн хориглосон бөлгөө; тиймийн тул би тэдгээрийг бичихгүй, учир нь тэд дэлхийгээс нуугдсан билээ.

26 Гэвч болгоогтун, би тэднийг харсан, мөн тэд надад тохинуулсан бөлгөө.

27 Мөн болгоогтун тэд харийнханы дунд байх болно,

мөн харийнхан тэднийг мэдэх нь үгүй.

28 Тэд түүнчлэн Иудейн дунд ч байх болно, мөн иудейчүүд тэднийг мэдэх нь үгүй.

29 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн өөрийн мэргэн ухаанд таарна хэмээн үзэхэд, тэд Израилын бүх “тараагдсан овгуудад, мөн бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүст тохинуулах болно, мөн тэдний хүсэл гүйцэлдэж болохын тулд, мөн түүнчлэн тэдэнд буй Бурханы итгүүлэх хүчний учир тэднээс олон бодгалийг Есүст авчрах болно.

30 Мөн тэд Бурханы “тэнгэр элчүүдийн адил, мөн хэрэв тэд Есүсийн нэрээр Эцэгт залбирах аваас тэд өөрсдийн хувьд сайн гэгдэх ямар ч хүмүүнд өөрсдийгөө үзүүлж чадна.

31 Тиймийн тул, бүх хүмүүс гарцаагүй Христийн шүүлтийн суудлын өмнө зогсох ёстой “агуу хийгээд ирэх өдрөөс өмнө тэднээр агуу хийгээд гайхамшигт үйлүүд хийгдэх болно;

32 Тийм ээ тэр шүүлтийн өдрийн өмнө тэднээр хийгдэх “агуу хийгээд гайхамшигт ажил бүр харийнханы дунд ч байх болно.

33 Мөн хэрэв Христийн бүх гайхамшигт ажлуудын шастырыг өгөх тэр бүх судрууд та нарт байсан аваас, та нар

20a Морм. 8:24.

21a Дан. 3:22–27;

4 Ниф. 1:32.

22a Дан. 6:16–23;

4 Ниф. 1:33.

23a су Сайн Мэдээ.

б 3 Ниф. 27:30–31.

25a 3 Ниф. 19:4.

29a су Израил—

Израилын

Тараагдалт;

Израил—Израилын

алдагдсан арван овог.

30a су Тэнгэр элчүүд.

31a Хил. 12:25;

3 Ниф. 26:4–5.

32a 2 Ниф. 25:17.

Христийн үгсийн дагуу, эдгээр зүйл гарцаагүй ирэх ёстойг мэдэх сэн билээ.

34 Мөн Есүсийн үгсийг “сонсохгүй түүнд, мөн түүнчлэн ⁶түүний сонгож мөн тэдний дунд илгээсэн тэдэнд халаг болог; учир нь Есүсийн үгсийг мөн түүний илгээсэн тэдний үгсийг хүлээн аваагүй хэн ч түүнийг хүлээн авахгүй; мөн тиймийн тул тэрээр эцсийн өдөр тэднийг хүлээн авахгүй байх болно;

35 Мөн тэдний хувьд хэрэв тэд төрөөгүй байсан бол илүү дээр байх сан. Учир нь хүмүүний “хөл дор дэвслэгдсэн тэрхүү, гомдсон Бурханы шударга ёсноос, түүгээр аврал ирж болох тэрнээс та нар зайлсхийж чадна хэмээн та нар бодно уу?

36 Мөн эдүгээ болгоогтун, Их Эзэний сонгосон тэдний, тийм ээ, бүр тэнгэрт шүүрэгдсэн тэр гурвын талаар, тэд зуурдын байдлаас үхэшгүй байдалд цэвэршүүлэгдсэн эсэхийг би мэдсэнгүй хэмээн би ярьсан учир —

37 Гэвч болгоогтун, бичсэнийхээ дараа, би Их Эзэнээс лавлаж, мөн тэрээр надад тэдний биесэд өөрчлөлт хийгдсэн байх ёстой, эсвээс тэд үхлийг амсах ёстой хэмээн надад илэрхийлсэн бөлгөө;

38 Тиймийн тул, тэд үхлийг амсаж болохгүйн тулд, тэд дэлхийн нүглүүдийн улмаас

бус аваас өвчнийг бас харамслыг амсахгүйн тулд тэдний биесэд “өөрчлөлт хийгдсэн ажээ.

39 Эдүгээ энэ өөрчлөлт нь эцсийн өдөр тохиох түүнтэй тэнцэх нь үгүй; харин тэдний дээр өөрчлөлт хийгдсэн, үүний хэрээр тэднийг давах хүчийг Сатан үл эзэмшсэнээс, тэрээр тэднийг “уруу татаж чадахгүй; мөн тэд бие махбодидоо ⁶ариусгагдсанаас ⁶ариун болж, мөн газар дэлхийн хүч тэднийг барьж чадахгүй болжээ.

40 Мөн энэ байдалд тэд Христийн шүүлтийн өдөр хүртэл үлдэх бөлгөө; мөн тэр өдөр тэд илүү агуу өөрчлөлтийг хүлээн авна, мөн Эцэгийн хаант улсад хойшид гарахгүйгээр хүлээн авагдана, тэгээд тэнгэрт Бурхантай мөнхөд орших болно.

БҮЛЭГ 29

Мормоны Номын ирэлт нь Их Эзэн Израилыг цуглуулж мөн гэрээнүүдээ гүйцэлдүүлж эхэлсний тэмдэг бөлгөө—Түүний хожмын үеийн илчлэлтүүд мөн бэлгүүдийг эсэргүүцдэг тэд зүхэгдэх болно. Ойролцоогоор мэ 34–35 он.

Мөн эдүгээ болгоогтун, би та нарт хэлнэ Их Эзэн өөрийн мэргэн ухаанд таарна хэмээн үзэхэд, эдгээр үгс түүний үгийн дагуу харийнханд

34a Ифер 4:8–12.
б су Бошиглогч.
35a Хил. 12:2.

38a су Зөөгдсөн хүмүүн биес.
39a су Уруу татах, Уруу

таталт.
б су Ариусгал.
в су Ариун байдал.

“ирэх болно, тэгээд өөрсдийн өвлөсөн нутаг дахь тэдний сэргээлтийн талаар Израилын хүүхдүүдтэй Эцэгийн хийсэн ⁶гэрээ аль хэдийн гүйцэлдэж эхэлснийг та нар мэднэ.

2 Мөн ариун бошиглогчдоор яригдсан, Их Эзэний үгс бүгд гүйцэлдэх болно гэдгийг та нар мэдэж болно; мөн Их Эзэн Израилын хүүхдүүдэд ирэхээ “хойшлуулна хэмээн та нар хэлэх хэрэггүй.

3 Мөн яригдсан үгс нь хоосон хэмээн та нар зүрх сэтгэлдээ төсөөлөх хэрэггүй, учир нь болгоогтун, Их Эзэн өөрийнх нь болох Израилын угсааны хүмүүстэй хийсэн гэрээгээ санах болно.

4 Мөн эдгээр үгс та нарын дунд ирэхийг харах үедээ, тэгээд та нар цаашид Их Эзэний үйлүүдийг жигшин эсэргүүцэх хэрэггүй, учир нь түүний “шударга ёсны ⁶илд баруун гарт нь байна; мөн болгоогтун, тэр өдөр, хэрэв та нар түүний үйлүүдийг жигшин эсэргүүцэх аваас тэрбээр энэ нь та нарыг удалгүй эзэрхийлэх болгоно.

5 Их Эзэний үйлүүдийг “жигшин эсэргүүцэх түүнд ⁶халаг; тийм ээ, Христийг

болон түүний ажлуудыг “үгүйсгэх түүнд халаг!

6 Тийм ээ, Их Эзэний илчлэлтүүдийг үгүйсгэх, мөн Их Эзэн илчлэлтээр, эсвээс бошиглолоор, эсвээс “бэлгээр, эсвээс хэлээр, эсвээс эдгээлтээр, эсвээс Ариун Сүнсний хүчээр ажиллахаа больсон хэмээн хэлэх түүнд ⁶халаг!

7 Тийм ээ, “баялгийг хураахын тулд, Есүс Христээр ⁶ямар ч гайхамшиг хийгдэх аргагүй хэмээн тэр өдөр хэлэх түүнд халаг; учир нь үүнийг хийх тэр нь Христийн үгийн дагуу, нигүүлсэл үгүй байсан сайхь ⁶мөхлийн хүүтэй адил болох болно!

8 Тийм ээ, “иудейчүүдийг, бас Израилын угсааны үлдэгдлийн хэнийг ч та нар цаашид ⁶шүд зуун хараах, бас “жигшин эсэргүүцэх ч, бас тохуурхах ч хэрэггүй; учир нь болгоогтун, Их Эзэн тэдэнтэй хийсэн гэрээгээ санадаг, мөн тэрбээр тангарагласныхаа дагуу тэдэнд үйлдэх болно.

9 Тиймийн тул тэрбээр Израилын угсаатай хийсэн гэрээний биелэлтэд хүргэн шүүлтийг гүйцэтгэхгүй байж болохын тулд, Их Эзэний баруун мутрыг зүүнээр нь өөрчилж чадна хэмээн та нар бодох хэрэггүй.

29 1а 2 Ниф. 30:3–8.

б Морм. 5:14, 20.

2а Лук 12:45–48.

4а су Шударга ёс.

б 3 Ниф. 20:20.

5а Морм. 8:17;

Ифер 4:8–10.

б 2 Ниф. 28:15–16.

в Мат. 10:32–33.

6а су Сүнсний

бэлгүүд.

б Морм. 9:7–11, 15.

7а су Санваараар

мэргэших.

б 2 Ниф. 28:4–6;

Морм. 9:15–26.

в су Мөхлийн

хүүхдүүд.

8а су Иудейчүүд.

б 1 Ниф. 19:14.

в 2 Ниф. 29:4–5.

БҮЛЭГ 30

Хожмын үеийн харийнхан наманчилж, Христэд ирэхээр, мөн Израилын угсаатай хамт тоологдохоор зарлиг болгогдов. Ойролцоогоор мэ 34–35 он.

Анхаарагтун, Ай харийнхан та нар, та нарын талаар ярихыг надад зарлиг болгосон амьд Бурханы Хүү, Есүс Христийн үгсийг сонсогтун, учир нь, болгоогтун тэрбээр бичихийг надад “зарлиг болгов, өгүүлсэн нь:

2 Бүх “харийнхан та нар, ёс бус замуудаасаа эргэгтүн; та нар нүглүүдийнхээ ангиж-

ралыг хүлээн авч, мөн Ариун Сүнсээр дүүргэгдэж болохын тулд, та нар Израилын угсааных болох миний хүмүүстэй хамт ⁶тоологдож болохын тулд мөн хилэнцэт үйлүүдээсээ, худал хэлэхээ мөн заль мэхүүдээ, мөн садар самуун үйлүүдээ, мөн нууц жигшүүрт хэргүүдээ, мөн хиймэл шүтээн шүтэхээ, мөн аллагуудаа, мөн санваараар мэргэших явдлаа, мөн атаа жөтөөгөө, мөн хэрүүл маргаанаа, мөн өөрсдийн бүх ёс бус явдлуудаа мөн жигшүүрт хэргүүдээ ⁶наманчлагтун, мөн надад ирж, мөн миний нэрээр баптисм хүрт.

ДӨРӨВДҮГЭЭР НИФАЙ НИФАЙН НОМ

ЕСҮС ХРИСТИЙН ШАВЬ НАРЫН НЭГ БОЛОХ НИФАЙН ХҮҮ БОЛОЙ.

Түүний цэдгийн дагуух, Нифайн хүмүүсийн шастир оршвой.

Нифайчууд мөн леменчүүд бүгдээр Христийн Сүмд Их Эзэнд хөрвүүлэгдэв—Тэд бүх зүйлийг нийтээр эзэмшин, гайхамшигийг үйлдэж, мөн уг нутагт дэгжив—Хоёр зууны дараа, хагарлууд, хилэнц, хуурамч сүмүүд, мөн хавчлагууд бий болов—Гурван зуун жилийн дараа, нифайчууд мөн леменчүүд аль аль нь ёс бус болсон байна—Аммарон ариун нандин цэдгүүдийг нуув. Ойролцоогоор МЭ 35–321 он.

МӨНХҮҮ улиран тохиох дор гучин дөрөв дэх он, мөн гучин тав дахь он улиран одож, мөн болгоогтун Есүсийн шавь нар Христийн сүмийг эргэн тойрны бүх нутагт байгуулав. Мөн тэдэн дээр ирсэн, мөн нүглүүдээсээ үнэнээр наманчилсан болгон нь, Есүсийн нэрээр баптисм хүртэв; мөн тэд түүнчлэн Ариун Сүнс хүлээн авав.

30 1а 3 Ниф. 5:12–13.
2а су Харийнхан.
6 Гал. 3:27–29;

2 Ниф. 10:18–19;
3 Ниф. 16:10–13;
21:22–25; Абр. 2:10.

6 су Наманчлах,
Наманчлал.

2 Мөнхүү улиран тохиох дор гучин зургаа дахь онд, нутгийн бүх гадаргуу дээр, уг хүмүүс, нифайчууд болон леменчүүд аль аль нь, бүгдээр Их Эзэнд хөрвүүлэгдэв, мөн тэдний дунд зөрчилдөөн мөн арцалдаан байсангүй, мөн хүмүүн бүр нэг нэгэнтэйгээ шударгаар харьцаж байлаа.

3 Мөн тэд өөрсдийн дунд “бүх зүйлийг нийтээр эзэмшиж байв; тиймийн тул баян ба ядуу, боол ба чөлөөт гэж байсангүй, харин тэд бүгдээр эрх чөлөөтэй, мөн тэнгэрлэг бэлгээс хүртэгсэд болгогдов.

4 Мөнхүү улиран тохиох дор гучин долоо дахь он түүнчлэн улиран одож, мөн уг нутагт амар амгалан үргэлжилсээр байв.

5 Мөн Есүсийн шавь нараар үйлдэгдсэн агуу хийгээд гайхамшигтай үйлүүд байв, үүний хэрээр тэд өвчтэйг “эдгээж, мөн үхсэнийг босгож, мөн доголонг алхдаг, мөн хараагүйг хараатай, мөн дүлийг сонсдог болгож байв; мөн бүх төрлийн ⁶гайхамшгуудыг тэд хүмүүний үрсийн дунд үйлдсэн буюу; мөн Есүсийн нэрээр бус аваас тэд юугаар ч гайхамшгуудыг үйлдсэн нь үгүй.

6 Мөн тийн гучин найм дахь, мөн түүнчлэн гучин ес дэх, мөн дөчин нэг дэх, мөн дөчин хоёр дахь он улиран одов,

тийм ээ, бүр дөчин есөн он улирч одох хүртэл, мөн түүнчлэн тавин нэг дэх, мөн тавин хоёр дахь; тийм ээ, мөн бүр тавин есөн он хүртэл улирч одсон ажгуу.

7 Мөн Их Эзэн тэднийг уг нутагт үлэмж дэгжүүлэв; тийм ээ, үүний хэрээр тэд хотууд шатаагдсан тэнд хотуудыг дахин барьсан буюу.

8 Тийм ээ, бүр агуу “хот Зарахемлаг тэд дахин баригдах болгов.

9 Гэвч “живүүлэгдсэн олон хот байв, мөн тэдгээрийн оронд ус байх болжээ; тиймийн тул эдгээр хотууд дахин шинэчлэгдэх аргагүй байв.

10 Мөн эдүгээ, болгоогтун, улиран тохиох дор Нифайн хүмүүс хүчирхэгжиж, мөн үлэмж түргэнээр өнөржиж, мөн тэд “үлэмж хонгорхон мөн бахдам сайхан хүмүүс болов.

11 Мөн тэд гэрлэж, мөн гэрлэхээр өгөгдөв, мөн Их Эзэн тэдэнд өгсөн олон тооны амлалтуудын дагуу адислагдав.

12 Мөн тэд “Мосегийн хуулийн гүйцэтгэл хийгээд ⁶ёслолуудын дагуу цаашид алхсангүй; гэвч тэд өөрсдийн Их Эзэн мөн өөрсдийн Бурханаас хүлээн авсан зарлигуудын дагуу алхаж, залбирч мөн Их Эзэний үгийг сонсохоор хамтдаа ойр ойрхон цугларахаа, мөн ⁶мацаг барилт

[4 НИФАЙ]

1 За Уйлс 4:32;

3 Ниф. 26:19.

су Өргөл болгох,

Өргөлийн хууль.

5а су Эдгээх, Эдгэрэх.

б Иохан 14:12.

су Гайхамшиг.

8а 3 Ниф. 8:8.

9а 3 Ниф. 9:4, 7.

10а Морм. 9:6.

12а 2 Ниф. 25:30;

3 Ниф. 15:2–8.

б су Мосегийн хууль.

в Моро. 6:5;

С ба Г 88:76–77.

мөн залбирлыг үргэлжлүүлсээр байв.

13 Мөнхүү улиран тохиох дор бүх нутагт, бүх хүмүүсийн дунд зөрчилдөөн огт үгүй байв; харин Есүсийн шавь нарын дунд үйлдэгдсэн сүр хүчит гайхамшгууд байлаа.

14 Мөнхүү улиран тохиох дор далан нэгдүгээр он улирч одов, мөн түүнчлэн далан хоёрдугаар он, тийм ээ, мөн эцэст нь далан есдүгээр оныг хүртэл улирч одов; тийм ээ, бүр зуун жил улирч одсон байв, мөн Есүсийн сонгосон шавь нар нь, үлдэх “гурваас бусад нь бүгд Бурханы ^бди-ваажинд одсон байв; мөн тэдний оронд өөр “шавь нар ‘томилогдов; мөн түүнчлэн уг үеийнхнээс олон нь талий-гаач болжээ.

15 Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн зүрх сэтгэлд орших Бурханы хайрын учир, уг нутагт “зөрчилдөөн огт байсангүй.

16 Мөн “атаа жөтөө, бас хэрүүл маргаан, бас үймээн, садар самуун ч, худал хэлэх нь ч, аллага ч, ямар ч төрлийн ^бшунал тачаал байсангүй; мөн Бурханы мутраар бүтээгдсэн бүх хүмүүсийн дунд илүү “аз жаргалтай хүмүүс байх аргагүй нь гарцаагүй юм.

17 Дээрэмчид ч, алуурчин-гууд ч, бас леменчүүд ч, бүр ямар ч -чууд байсангүй, ха-

рин тэд, Христийн хүүхдүүд, мөн Бурханы хаант улсын өв залгамжлагчид гэгдэн “нэг болсон байв.

18 Мөн хичнээн их адислагдсан билээ тэд! Учир нь Их Эзэн тэдний бүх үйлд тэднийг адисалсан болой; тийм ээ, бүр зуун арван жил улирч одох хүртэл тэд адислагдан мөн дэгжээгдсэн буюу; мөн Христээс хойш эхний үе улирч одсон байв, мөн бүх нутагт зөрчилдөөн огт байсангүй.

19 Мөнхүү улиран тохиох дор Нифай, энэхүү сүүлчийн цэдгийг хөтөлсөн тэрээр, (мөн тэрбээр үүнийг Нифайн “ялтсууд дээр хөтөлсөн буюу) нас нөгчив, мөн түүний хүү Амос түүний оронд үүнийг хөтлөв; мөн тэрбээр үүнийг түүнчлэн Нифайн ялтсууд дээр хөтөлсөн ажээ.

20 Мөн тэрбээр үүнийг наян дөрвөн жил хөтөлж, мөн уг нутагт, сүмээс дайжиж мөн леменчүүдийн нэрийг өөрсөд дээрээ авсан хүмүүсийн багахан хэсгээс бусдаар, амар амгалан байсаар байв; тиймийн тул уг нутагт дахин леменчүүд гэж бий болж эхлэв.

21 Мөнхүү улиран тохиох дор түүнчлэн Амос нас нөгчиж, (мөн энэ нь Христийн ирснээс хойш зуун ерэндөрвөн жил байсан буюу) мөн түүний хүү Амос түүний оронд уг цэдгийг хөтлөв; мөн

14a 3 Ниф. 28:3–9.

су Зөөгдсөн хүмүүн биес.
б су Диваажин.
в су Шавь.
г су Томилох,

Томилолт.
15a су Амар амгалан.
16a су Эв нэгдэл.
б су Тачаадах.
в Мозая 2:41;
Алма 50:23.

су Баяр баясгалан.
17a Иохан 17:21.
су Сион.
19a су Ялтсууд.

тэрбээр үүнийг Нифайн ялт-сууд дээр хөтлөв; мөн энэ нь бас, энэ ном болох Нифайн номонд бичигдсэн бөлгөө.

22 Мөнхүү улиран тохиох дор хоёр зуун жил улирч одсон байв; мөн цөөхөн хэдээс бусдаар хоёр дахь үеийнхэн бүгд талийгаач болсон байв.

23 Мөн эдүгээ би, Мормон, уг хүмүүс өнөржсөн, үүний хэрээр уг нутгийн бүхэл гадаргуу дээгүүр тархсан, мөн Христ дэх дэгжлийнхээ улмаас тэд үлэмж баян болсныг та нар мэдээсэй хэмээнэ.

24 Мөн эдүгээ, энэхүү хоёр зуун нэг дэх онд тэдний дунд, үнэтэй өмсгөл өмсөх, мөн бүх төрлийн тансаг сувд, мөн ертөнцийн тансаг эдлэлүүдээс өмсөх гэх мэтээр “бардамналд хөөргөгдсөн тэд байж эхлэв.

25 Мөн тэр цагаас хойш тэд өөрсдийн эд агуурс хийгээд өмч хөрөнгөө дундаа “нийтээр эзэмшихээ болив.

26 Мөн тэд зиндаагаар хуваагдаж эхлэв; мөн тэд “ашиг олохын тулд өөрсдөдөө ^бсүм барьж эхлэв, мөн Христийн үнэн сүмийг үгүйсгэж эхлэв.

27 Мөнхүү улиран тохиох дор хоёр зуун арван жил улирч одсон үед уг нутагт олон сүм байв; тийм ээ, Христийг мэднэ хэмээн тунхагладаг авч түүний сайн мэдээний ихээхэн хэсгийг “үгүйсгэж, үүний

хэрээр тэд бүх төрлийн ёс бусын үйлийг хүлээж авч, мөн зохисгүй байдлынх нь улмаас түүнийг хүртэх нь ^бхориглогдсон нэгэнд, ариун нандин болох түүнийг хүртээж байсан олон сүм байлаа.

28 Мөн энэ “сүм алдсын улмаас, мөн тэдний зүрх сэтгэлийг эзэмдсэн Сатаны хүчний улмаас үлэмж дэвжив.

29 Мөн түүнчлэн, Христийг үгүйсгэсэн өөр нэгэн сүм байв; мөн тэд Христийн үнэн сүмийг, тэдний даруу байдал хийгээд Христэд итгэх тэдний итгэлийнх нь улмаас “хавчиж байв; мөн тэдний дунд үйлдэгдсэн олон гайхамшигийн улмаас тэд тэднийг үзэн яддаг байв.

30 Тиймийн тул тэдэнтэй үлдсэн Есүсийн шавь нарын дээр хүч болон эрх мэдлийг тэд хэрэгжүүлэн, мөн тэднийг “шоронд хаяв; гэвч тэдэнд байсан Бурханы үгийн хүч чадлаар, шоронгууд хоёр хуваагдан цуурч, мөн тэдний дунд хүчит гайхамшгуудыг тэд үйлдэн явцгаасан бөлгөө.

31 Гэсэн хэдий ч, мөн эдгээр бүх гайхамшиг байсан хэдий ч, хүмүүс зүрх сэтгэлээ хатууруулж, мөн өөрийнх нь үгийн дагуу, Иерусалим дахь иудейчүүд Есүсийг хөнөөхөөр эрэлхийлсний адилаар, тэднийг алахаар эрэлхийлж байв.

32 Мөн тэд тэднийг “галт

24a су Бардамнал.

25a 4 Ниф. 1:3.

26a 1 Ниф. 22:23;

2 Ниф. 28:3;

Морм. 8:32–38.

б С ба Г 10:56.

су Санваараар

мэргэших.

27a су Урвалт.

б 3 Ниф. 18:28–29.

28a су Чөтгөр—

Чөтгөрийн сүм.

29a су Хавчих,

Хавчлага.

30a 3 Ниф. 28:19–20.

32a Дан. 3:26–27.

⁶зууханд хаяж, мөн тэд гэмтлэггүйгээр гарч иржээ.

33 Мөн тэд түүнчлэн тэднийг зэрлэг араатны “үүрэнд хаясан ч, мөн тэд хургатай тоглож буй хүүхэд лугаа адил зэрлэг араатнуудтай тоглов; мөн тэд гэмтэл авалгүй, тэдний дундаас гарч ирэв.

34 Гэсэн хэдий ч, хүмүүс зүрх сэтгэлээ хагууруулав, учир нь олон санваартан мөн хуурамч бошиглогчдоор олон сүм баригдахад, мөн бүх төрлийн алдсыг үйлдэхэд тэд удирдагдав. Мөн тэд Есүсийн хүмүүсийг “цохив; гэвч Есүсийн хүмүүс хариуд нь буцааж цохьсонгүй. Мөн ийн тэд жилээс жилд, бүр хоёр зуун гучин жил улирч одох хүртэл, итгэлгүйдээ мөн ёс бусын үйлдээ бууран доройтов.

35 Мөн эдүгээ улиран тохиох дор тэр онд, тийм ээ, хоёр зуун гучин нэг дэх онд, хүмүүсийн дунд нэгэн агуу хагарал болов.

36 Мөнхүү улиран тохиох дор тэрхүү онд нифайчууд хэмээн нэрлэгдсэн хүмүүс гарч ирэв, мөн тэд Христэд үнэн итгэгчид байв; мөн тэдний дунд леменчүүдээр нэрлэгдсэнээр — иаковчууд, иосефчүүд, зорамчууд болох тэд байв;

37 Тиймийн тул Христэд үнэн итгэгсэд, мөн Христийг үнэн бишрэн шүтэгсэд, (үлдэх болсон Есүсийн “гурван шавь тэдний дунд байсан

буюу) нь нифайчууд, мөн иаковчууд, мөн иосефчүүд, мөн зорамчууд хэмээн нэрлэгддэг байсан бөлгөө.

38 Мөнхүү улиран тохиох дор сайн мэдээг эсэргүүцсэн тэд леменчүүд, мөн лемүелчүүд, мөн ишмэилчүүд хэмээн нэрлэгддэг байв; мөн тэд итгэлгүйдээ бууран доройтсон бус, харин тэд Христийн сайн мэдээний эсрэг санаатайгаар “эсэргүүцэж байв; мөн бүр тэдний эцэг өвгөд нь эхлэлээс бууран доройтсоны адилаар, тэд итгэх ёсгүй хэмээн хүүхдүүддээ заадаг байв.

39 Мөн энэ нь бүр эхлэлд байсны адилаар, тэдний эцэг өвгөдийн ёс бус хийгээд жигшүүрт үйлийн улмаас байсан буюу. Мөн, эхлэлээс леменчүүд Нифайн хүүхдүүдийг үзэн ядахыг заалгасны адилаар, тэд Бурханы хүүхдүүдийг үзэн ядахыг “заалгасан ажгуу.

40 Мөнхүү улиран тохиох дор хоёр зуун дөчин дөрвөн жил улирч одсон байв, мөн хүмүүсийн хэрэг явдал тийн байв. Мөн хүмүүсийн илүү ёс бус хэсэг нь хүчирхэгжиж, мөн Бурханы хүмүүсээс үлэмж илүү олон тоотой болов.

41 Мөн тэд өөрсдөдөө сүмүүдийг барьсаар, мөн тэдгээрийг бүх төрлийн үнэт зүйлээр чимэглэсээр байв. Мөн тийн хоёр зуун тавин жил, мөн түүнчлэн хоёр зуун жаран жил улиран одов.

32б 3 Ниф. 28:21.

33а 3 Ниф. 28:22.

34а 3 Ниф. 12:39;

С ба Г 98:23–27.

37а 3 Ниф. 28:6–7;

Морм. 8:10–11.

38а су Эсэргүүцэл.

39а Мозая 10:17.

42 Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн ёс бус хэсэг нь Гадантоны нууц тангараг хийгээд “хуйвалдааныг дахин байгуулж эхлэв.

43 Мөн түүнчлэн Нифайн хүмүүс гэж нэрлэгддэг асан тэдгээр хүмүүс, үлэмж баялгийнхаа улмаас, зүрх сэтгэлдээ бардамнаж эхлэв, мөн өөрсдийн ахан дүүс леменчүүдийн адилаар, хоосон сагсуурах болов.

44 Мөн энэ цагаас шавь нар дэлхийн “нүглүүдийн төлөө гашуудаж эхлэв.

45 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун жил улирч одоход, Нифайн хүмүүс болоод леменчүүдийн аль аль нэг нь нөгөөгийнхээ адилаар үлэмж ёс бус болцгоосон байв.

46 Мөнхүү улиран тохиох дор Гадантоны дээрэмчид нутгийн бүх гадаргуу дээгүүр тархав; мөн Есүсийн шавь нараас өөр зөв шударга нэгэн байсангүй. Мөн алт мөн мөнгийг тэд элбэг дэлбэгээр

хадгалан агуулж, мөн бүх төрлийн арилжаанд наймаалцаж байлаа.

47 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун таван жил улирч одсоны дараа, (мөн уг хүмүүс ёсон бусад үлдсэн хэвээр байв) Амос нас нөгчив; мөн түүний дүү, Аммарон, түүний оронд цэдгийг хөтлөв.

48 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун хорин жил улирч одсоны дараа, Аммарон, Ариун Сүнсээр албадуулагдан, нандин цэдгүүдийг — тийм ээ, бүр ариун нандин болох, үеэс үед гардуулагдан ирсэн, тэрхүү бүх ариун нандин “цэдгийг — бүр Христийн ирэлтээс гурван зуун хорь дахь оныг хүртэлхийг нуув.

49 Мөн тэдгээр нь Их Эзэний бошиглол мөн амлалтуудын дагуу, Иаковын угсааны үлдэгдэлд “дахин ирж болохын тул, тэрбээр тэдгээрийг Их Эзэний төлөө нуусан бөлгөө. Мөн Аммароны цэдгийн төгсгөл ийн байв.

Мормоны Ном

БҮЛЭГ 1

Ариун нандин цэдгүүдийн талаар Аммарон Мормонд зааварлав — Нифайчууд болон леменчүүдийн хооронд дайн дэгдэв — Нифай үндэстэн болох Гурав холдуу-

лагдан авагдав — Ёс бус явдал, үл итгэх байдал, илбэ шидүүд, мөн шулмын арга газар авав. Ойролцоогоор мэ 321–326 он.

МӨН эдүгээ би, “Мормон, Мөөрийн үзэж бас сонссон

42a су Нууц
хуйвалдаанууд.
44a 3 Ниф. 28:9.

48a Хил. 3:13, 15–16.
49a Инос 1:13.
[МОРМОН]

1 1a су Мормон,
Нифайчуудын
бошиглогч.

зүйлүүдийн ^бцэдгийг бүтээе, мөн үүнийг Мормоны Ном хэмээн нэрлэе.

2 Мөн “Аммарон Их Эзэний төлөө цэдгүүдийг нуусан тэр үеийн орчим, тэрбээр надад ирж, (би арав орчим настай, мөн өөрийн хүмүүсийн эрдэм мэдлэгийн дагуу би ямар нэг хэмжээгээр ^бсуралцаж эхэлсэн байв) мөн Аммарон надад хэлсэн нь: Чи бол хэрсүү хүүхэд, мөн ажиглан ойлгохдоо түргэн болохыг би ухамсарлаж байна;

3 Тиймийн тул, чи хорин дөрөв орчим настай болох үедээ, энэ хүмүүсийн талаар ажигласан зүйлүүдээ чамайг санаасай хэмээн би хүснэ; мөн тэр насандаа чи Антамын нутаг тийш, “Шим хэмээн нэрлэгдэх толгойг хүртэл явагтун; мөн энэ хүмүүсийн талаарх бүх ариун нандин сийлбэрүүдийг Их Эзэний төлөө би тэнд хадгалсан буй.

4 Мөн болгоогтун, чи Нифайн “ялтсуудыг өөртөө авах болно, мөн үлдсэнийг нь тэдгээрийн байгаа тэр газарт нь үлдээх болно; мөн чи Нифайн ялтсууд дээр энэ хүмүүсийн талаар өөрийн ажигласан бүх зүйлүүдийг сийлбэрлэх болно.

5 Мөн би, Мормон, Нифайн “удам болохоор, (мөн миний эцгийн нэр нь Мормон байсан буюу) Аммарон надад зарлиг болгосон зүйлүүдийг би санав.

6 Мөнхүү улиран тохиох дор би, арваннэгэн настай байхдаа, өмнө зүгийн нутаг тийш, бүр Зарахемлагийн нутагт эцгээрээ хүргэгдэв.

7 Уг нутгийн бүх гадаргуу нь барилгуудаар бүрхэгдсэн байж, мөн хүмүүс нь бараг л тэнгисийн элс мэт олон тоотой байв.

8 Мөнхүү улиран тохиох дор энэ онд, нифайчууд болон иаковчууд, мөн иосефчүүд, мөн зорамчуудаас бүрдсэн нифайчууд дайнд оров; мөн энэ дайн нь нифайчууд, мөн леменчүүд болон лемүелчүүд түүнчлэн ишмэилчүүдийн хооронд байсан бөлгөө.

9 Эдүгээ леменчүүд болон лемүелчүүд мөн ишмэилчүүд нь леменчүүд хэмээн нэрлэгдэж, мөн хоёр тал нь нифайчууд болон леменчүүд байв.

10 Мөнхүү улиран тохиох дор тэдний дунд Зарахемлагийн хил дээр, Сидоны усны дэргэд, дайн эхлэв.

11 Мөнхүү улиран тохиох дор нифайчууд агуу тооны, бүр гучин мянгаас давах тооны эрчүүдийг нэгтгэн цуглуулсан байв. Мөнхүү улиран тохиох дор тэрхүү жилд нифайчууд, леменчүүдийг цохин мөн тэднээс олныг нь хөнөөсөн хэд хэдэн тулалдаанд оров.

12 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд төлөвлөснөө орхиж, мөн уг нутагт амар амгалан тогтов; мөн тэрхүү амар амгалан нь дөрвөн жил

1б 3 Ниф. 5:11–18.
2а 4 Ниф. 1:47–49.
б Мозая 1:3–5.

3а Ифер 9:3.
4а Мор. үгс 1:1, 11.
су Ялтсууд.

5а 3 Ниф. 5:12, 20.

орчмын туршид байв, тиймээс ямар ч цус урссангүй.

13 Гэвч бүх нутгийн гадаргуу дээр ёс бус үйл газар авч, үүний хэрээр Их Эзэн өөрийн “хайрт шавь нарыг холдуулан авч, мөн гайхамшгийн болоод эдгээх үйлүүд хүмүүсийн алдсын улмаас байхаа болив.

14 Мөн тэдний ёс бус үйл мөн “үл итгэх байдлын улмаас, Их Эзэнээс ямар ч бэлэг байсангүй, мөн “Ариун Сүнс хэний ч дээр ирсэнгүй.

15 Мөн би, арван таван настай байхдаа мөн ямартай ч хэрсүү ухаантай байсны учир, тиймийн тул би Их Эзэнээр зочлогдон, мөн Есүсийн сайн сайхныг амталж мөн мэдэв.

16 Мөн би энэ хүмүүст номлохыг хичээв, гэвч миний ам хаагдаж, мөн би тэдэнд номлох нь хориглогдов; учир нь болгоогтун тэд Бурханаа санаатайгаар “эсэргүүцэж байв; мөн тэдний алдсын улмаас хайрт шавь нар нь уг нутгаас б⁶холдуулан авагдсан бөлгөө.

17 Гэвч би тэдний дунд үлдэв, харин тэдний зүрх сэтгэл хатуугийн улмаас, би тэдэнд номлох нь хориглогдсон буюу; мөн тэдний зүрх сэтгэлийн хатуугийн улмаас уг нутаг тэдний улмаас “зүхэгдсэн бөлгөө.

18 Мөн леменчүүдийн дунд байсан Гадиантоны дээрэмчид уг нутагт бужигналдан, үүний хэрээр үүний оршин

суугчид “эд баялгаа газарт нууж эхлэв; мөн Их Эзэн уг нутгийг зүхсэний улмаас, тэдгээр нь гулгамтгай болж, тиймээс тэд дахин тэдгээрийг барьж, бас эзэмшин үлдээж чадсангүй.

19 Мөнхүү улиран тохиох дор ид шидүүд, мөн шулмын арга, мөн илбэ байв; мөн бүх нутгийн гадаргуу дээр, бүр Абинадай, мөн түүнчлэн лемен үндэстэн Самуелын бүх үгсийн биелэл болон уг хилэнцэт нэгний хүч чадал үйлдэгдэж байв.

БҮЛЭГ 2

Мормон нифайчуудын их цэргийг удирдав—Цус мөн хядаан уг нутгийг бүрхэв—Нифайчууд яллагдагсдын харамслаар гишүүдаж мөн гаслав—Тэдний ач ивээлийн өдөр улирч одов—Мормон Нифайн ялтсуудыг олж авав—Дайнууд үргэлжлэв. Ойролцоогоор мэ 327–350 он.

Мөнхүү улиран тохиох дор тэр нэгэн жилд нифайчууд болон леменчүүдийн хооронд дахин дайн эхлэв. Мөн би залуу байсан хэдий ч, биеэр том байв; тиймийн тул Нифайн хүмүүс намайг өөрсдийн удирдагч, өөрөөр хэлбэл их цэргийнхээ удирдагчаар томилов.

2 Тиймийн тул улиран тохиох дор би арван зургаа дахь

13а 3 Ниф. 28:2, 12.

14а су Итгэлгүй байдал.

б Моро. 10:8–18, 24.

в су Ариун Сүнс.

16а су Эсэргүүцэл.

б Морм. 8:10.

17а 2 Ниф. 1:7;

Алма 45:10–14, 16.

18а Хил. 13:18–20;

Ифер 14:1–2.

насандaa нифайчуудын их цэргийн тэргүүнд, леменчүүдийн эсрэг явсан билээ; тиймийн тул гурван зуун хорин зургаан жил улиран одсон байв.

3 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун хорин долоо дахь онд леменчүүд бидний дээр үлэмж агуу хүчээр ирж, үүний хэрээр тэд миний их цэргийг сүрдүүлэв; тиймийн тул тэд тулалдсангүй, мөн тэд умард нутгуудыг чиглэн ухарч эхлэв.

4 Мөнхүү улиран тохиох дор бид Анголын хотод ирээд, мөн бид хотыг эзэмшилдээ авч, мөн леменчүүдээс өөрсдийгөө хамгаалахаар бэлтгэл хийв. Мөнхүү улиран тохиох дор бид өөрсдийн хүчээр хотыг бэхлэв; бидний бүх бэхлэлт байсан хэдий ч леменчүүд бидний дээр ирж мөн биднийг уг хотоос зайлуулав.

5 Мөн тэд түүнчлэн биднийг Давидын нутгаас зайлуулав.

6 Мөн бид жагсан алхаж мөн, тэнгисийн эргийн дэргэд өрнөд хилд байх Иошуагийн нутагт ирэв.

7 Мөнхүү улиран тохиох дор бид тэднийг нэгтгэн хамтагаж болохын тулд, өөрсдийн хүмүүсийг аль болох хурднаар цуглуулав.

8 Гэвч болгоогтун, уг нутаг дээрэмчдээр мөн леменчүүдээр дүүрсэн байв; мөн миний хүмүүсийн дээгүүр нүүрлэх агуу устгал байсан хэдий ч, тэд хилэнцэт үйлүүдээ наманчилсангүй; тиймийн тул нифайчуудын тал

мөн түүнчлэн леменчүүдийн талын аль алинд нь, нутгийн бүх гадаргуу дээгүүр, цус мөн хядаан тархав; мөн энэ нь уг нутгийн бүх гадаргуу дээгүүр бүхнийг хамарсан үймээн байв.

9 Мөн эдүгээ, леменчүүд хаантай байлаа, мөн түүний нэр Аарон байв; мөн тэрбээр бидний эсрэг дөчин дөрвөн мянган цэрэг эрстэйгээр ирэв. Мөн болгоогтун, дөчин хоёр мянгатайгаа би түүнийг сөрөн зогсов. Мөнхүү улиран тохиох дор би түүнийг өөрийн их цэрэгтэйгээ дийлснээс тэрбээр миний өмнө зугтав. Мөн болгоогтун, энэ бүхэн тохиож, мөн гурван зуун гучин жил улирч одсон байлаа.

10 Мөнхүү улиран тохиох дор бошиглогч Самуелын бошиглосончлон нифайчууд алдсаа наманчилж эхлэв, мөн уйлж эхлэв; учир нь болгоогтун, уг нутагт байсан хулгайч нар, мөн дээрэмчид, мөн алуурчид, мөн илбийн ид шид, мөн шулмын аргын учир хэн ч өөрийн болох юуг ч хадгалж чадахгүй байлаа.

11 Тийн бүх нутагт, мөн ялангуяа Нифайн хүмүүсийн дунд эдгээр зүйлүүдийн улмаас гашуудал мөн гаслан байж эхлэв.

12 Мөнхүү улиран тохиох дор би, Мормон, Их Эзэний өмнөх тэдний гашуудал мөн тэдний гаслан мөн тэдний харууслыг үзээд, дотроо зүрх сэтгэлдээ баясч эхлэв, Их Эзэний нигүүлсэл хийгээд тэсвэрийг мэдсэний учир,

тиймийн тул тэд дахин зөв шударга хүмүүс болохын тулд тэрбээр тэдэнд нигүүлсэнгүй хандах болов уу хэмээн бодов.

13 Гэвч болгоогтун миний энэ баяр хөөр хий хоосон байв, учир нь тэдний “харуусал Бурханы сайн сайхны улмаас наманчлалд хүргэсэнгүй; харин, нүгэлдээ ^баз жаргалыг хүртэхийг нь Их Эзэн тэдэнд байнга эс зөвшөөрдгийн улмаас энэ нь ^вяллагдагсдын харуусал байсан буюу.

14 Мөн тэд харууссан “зүрх мөн гэмшсэн сэтгэлтэйгээр Есүст ирсэнгүй, харин тэд Бурханыг ^бзүхэж, мөн үхэхийг хүсч байв. Гэсэн хэдий ч тэд амьдралынхаа төлөө илдээр тэмцэх болно.

15 Мөнхүү улиран тохиох дор миний харуусал дахин надад ирж, мөн “ач ивээлийн ^бөдөр тэдний хувьд, биеийн мөн сүнсний хувьд ч ^вөнгөрсөн болохыг би харсан юм; учир нь тэдний мянга мянгыг Бурханаа илтээр эсэргүүцээд унагаагдахыг, мөн уг нутгийн гадаргуу дээр өтөг бууц мэт овоологдохыг харсан буюу би. Мөн тийн гурван зуун дөчин дөрвөн жил улирч одсон байв.

16 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун дөчин тав дахь онд нифайчууд леменчүүдийн өмнө зугтаж эхлэв; мөн

тэдний ухралтанд тэднийг зогсоох боломжтой болохын өмнө, тэд бүр Жашоны нутагт ирэх хүртлээ мөрдөгдсөн ажгуу.

17 Мөн эдүгээ, Жашоны хот нь Аммарон цэдгүүдийг, тэдгээр нь устгагдахгүй байж болохын тулд, Их Эзэний төлөө хадгалсан тэр “нутгийн ойр байв. Мөн болгоогтун би Аммароны үгийн дагуу явж, мөн Нифайн ялтсуудыг авч, мөн Аммароны үгсийн дагуу цэдгийг үйлдэв.

18 Мөн Нифайн ялтсууд дээр би бүх ёс бус хийгээд жигшүүрт хэргүүдийн бүрэн шастирыг бичсэн болой; гэвч эдгээр “ялтсууд дээр би тэдний ёс бус хийгээд жигшүүрт хэргүүдийн бүрэн шастирыг үйлдэхээс татгалзав, учир нь болгоогтун, би хүмүүний замналыг болгоох болсон тэр цагаас ёс бус хийгээд жигшүүрт хэргүүдийн үргэлжийн дүр зураг нүдний минь өмнө байсан буюу.

19 Мөн тэдний ёс бусын улмаас би халаглаж байна; учир нь миний бүх өдрүүдэд, тэдний ёс бусын улмаас зүрх сэтгэл минь харууслаар дүүрсээр ирсэн юм; гэсэн хэдий ч, эцсийн өдөр “өргөгдөх болно гэдгээ би мэднэ.

20 Мөнхүү улиран тохиох дор энэ жилд Нифайн хүмүүс дахин мөрдөгдөж мөн хөөгдөв.

2 13а 2 Кор. 7:10;

Алма 42:29.

б Алма 41:10.

в су Ял.

14а су Харууссан зүрх.

б су Доромжлох,

Доромжлол.

15а су Ач ивээл.

б Хил. 13:38.

в Иер. 8:20;

С ба Г 56:16.

17а Морм. 1:1–4.

18а су Ялтсууд.

19а Мозая 23:22;

Ифер 4:19.

Мөнхүү улиран тохиох дор бид Шем хэмээн нэрлэгдэх умард зүгийн нутагт ирэх хүртлээ бид хөөгдсөн буюу.

21 Мөнхүү улиран тохиох дор бид Шем хотыг бэхлэв, мөн бид тэднийг устгагдахаас аварч магадын тул, бид аль болох олноор боломжийн хэрээр өөрсдийн хүмүүсийг цуглуулсан болой.

22 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун дөчин зургаа дахь онд тэд бидний дээр дахин ирж эхлэв.

23 Мөнхүү улиран тохиох дор би өөрийн хүмүүстэй ярьж, мөн тэд леменчүүдийн өмнө өөрсдийн эхнэр, мөн өөрсдийн хүүхдүүд, мөн өөрсдийн байшин, мөн гэр орныхоо төлөө зоригтойгоор “зогсохыг агуу эрч хүчээр тэдэнд уриалав.

24 Мөн миний үгс тэднийг ямартай ч зоригжуулан босгож, үүний хэрээр тэд леменчүүдийн өмнө зугтсангүй, харин тэдний эсрэг зоригтойгоор зогсов.

25 Мөнхүү улиран тохиох дор гучин мянгатай их цэрэгтэйгээр бид тавин мянгатай их цэргийн эсрэг тэмцсэн юм. Мөнхүү улиран тохиох дор тэд бидний өмнө зугтах болсон тийм тууштайгаар бид тэдний өмнө зогсов.

26 Мөнхүү улиран тохиох дор тэднийг зугтахад бид тэднийг их цэрэгтэйгээ мөрдөн хөөж, мөн тэдэнтэй дахин тулав, мөн тэднийг бут цохьсон буюу; гэсэн хэдий ч Их

Эзэний хүч бидэнтэй хамт байсангүй; тийм ээ, Их Эзэний Сүнс бидэнтэй эс үлдсэнээс бид өөрсдөдөө л найдах болов; тиймийн тул бид ахан дүүсийнхээ адил сул дорой болсон байв.

27 Мөн миний хүмүүсийн, тэдний ёс бус хийгээд тэдний жигшүүрт хэргүүдийн улмаас, энэ агуу гай гамшгийн улмаас, зүрх сэтгэл минь харуусав. Гэвч болгоогтун, бид леменчүүдийн мөн Гадиантоны дээрэмчдийн эсрэг, бид дахин өвийн нутгуудаа эзэмшилдээ авах хүртлээ явсан бөлгөө.

28 Мөн гурван зуун дөчин ес дэх он улирч одов. Мөн гурван зуун тавь дахь онд бид леменчүүд хийгээд Гадиантоны дээрэмчидтэй хэлцэл байгуулж, түүгээр өвийн нутгуудаа бид хуваалгав.

29 Мөн леменчүүд, тийм ээ, бүр өмнөд нутагт хөтлөх “нарийн гарц хүртлэх умард зүгийн нутгийг бидэнд өгсөн бөлгөө. Мөн бид өмнө зүгийн бүх нутгийг леменчүүдэд өгөв.

БҮЛЭГ 3

Мормон нифайчуудад наманчлалыг тунхаглав — Тэд агуу ялалтыг олж мөн хүчиндээ бахдан хөөрөв — Мормон тэднийг удирдахаас татгалзав, мөн тэдний төлөөх түүний залбирлууд итгэлгүй байв — Мормоны Ном Израилын арванхоёр овгийг сайн

мэдээнд итгэхийг урьдаг. Ойролцоогоор мэ 360–362 он.

Мөнхүү улиран тохиох дор леменчүүд арван жил улирч одох хүртэл дахин тулалдахаар ирсэнгүй. Мөн болгоогтун, би өөрийн хүмүүс, нифайчуудыг, нутгаа мөн зэр ээвсгээ тулааны цагт бэлтгэхээр хөдөлмөрлүүлэв.

2 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн надад хэлэв: Энэ хүмүүст ийн тунхагла—Наманчлагтун та нар, мөн надад ирэгтүн, мөн баптисм хүртэгтүн та нар, мөн миний сүмийг дахин байгуулагтун, мөн та нар хэлтрүүлэгдэх болно.

3 Мөн би энэ хүмүүст тунхаглав, гэвч энэ нь хий хоосон болов; мөн тэднийг хэлтрүүлсэн, мөн тэдэнд наманчлалын боломж олгосон нь Их Эзэн байсныг тэд ухаарсангүй. Мөн болгоогтун тэд Их Эзэн Бурханыхаа эсрэг зүрх сэтгэлээ хатууруулжээ.

4 Мөнхүү улиран тохиох дор Христийн ирэлтээс хойш, бүхэлдээ гурван зуун жаран жил болж, энэ арав дахь жил улирч одсоны дараа, тэд дахин бидний эсрэг тулалдахаар бэлтгэж байгааг леменчүүдийн хаан надад мэдэгдсэн захидал илгээв.

5 Мөнхүү улиран тохиох дор би Эзгүйрэлийн нутагт, хил дээр орших хотод, өмнө зүгийн нутаг тийш хөтөлсөн нарийн гармын ойр өөрийн хүмүүсийг цугларах болгов.

6 Мөн бид леменчүүдийн их цэргийг зогсоож болохын тул, тэд бидний аль ч нутгийг эзэмшилдээ авахгүй байж болохын тулд, бид тэнд өөрсдийн их цэргийг байрлуулав; тиймийн тул бид бүх хүчээрээ тэдний эсрэг бэхлэлт босгов.

7 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун жаран нэг дэх онд леменчүүд бидний эсрэг тулалдахаар уруудан Эзгүйрэлийн хотод ирэв; мөнхүү улиран тохиох дор тэр жилд бид тэднийг ялж, үүний хэрээр тэд дахин нутагтаа буцав.

8 Мөн гурван зуун жаран хоёр дахь онд тэд тулалдахаар дахин уруудан ирэв. Мөн бид тэднийг дахин ялж, мөн тэднээс агуу олныг хөнөөж, мөн тэдний үхэгсэд тэнгист хаягдсан буюу.

9 Мөн эдүгээ, миний хүмүүс, нифайчуудын үйлдсэн энэ агуу зүйлийн улмаас, тэд хүчиндээ “сагсуурч эхлэн, мөн тэнгэрийн өмнө, дайснуудаараа хөнөөгдсөн ах дүүсийнхээ цусны өшөөг тэд авах болно хэмээн тангараглаж эхлэв.

10 Мөн тэд дайсныхаа эсрэг “тулалдахаар явж мөн уг нутгийн гадаргуу дээрээс арилгах болно хэмээн тэд тэнгэрээр, мөн түүнчлэн Бурханы сэнтийгээр тангараглаж байв.

11 Мөнхүү улиран тохиох дор би, Мормон, тэдний ёсон бус мөн жигшүүрт хэргийн улмаас, энэ цагаас энэ хүмүү-

сийн ахлагч бөгөөд удирдагч байхаас бүрнээ татгалзав.

12 Болгоогтун, би тэднийг удирдсан, тэдний ёс бус үйл байсан хэдий ч би тэднийг олон удаа тулалдаанд удирдсан, мөн надад байсан Бурханы “хайрын дагуу тэднийг бүх зүрх сэтгэлээрээ хайрладаг байв; мөн бодгаль минь өөрийн Бурханд тэдний төлөө бүх өдрийн уртад залбиралд цутгагдсан билээ; гэсэн хэдий ч, тэдний зүрх сэтгэл хатуугийн улмаас, энэ нь ^битгэлгүй байв.

13 Мөн гурвантаа би тэднийг дайснуудынх нь гараас гаргаж авав, мөн тэд нүглүүдээсээ наманчилсангүй.

14 Мөн тэд дайсныхаа эсрэг тулалдахаар явж, мөн ахан дүүсийнхээ цусны өшөөг авна хэмээн, бидний Их Эзэн мөн Аврагч Есүс Христээр тэдэнд “хориглогдсон тэр бүгдээр тэд тангарагласны дараа, болгоогтун Их Эзэний дуу хоолой надад ирж, хэлсэн нь:

15 “Өшөө авалт бол минийх, мөн би ^бхариу төлөх болно; мөн би тэднийг чөлөөлсний дараа энэ хүмүүс наманчлаагүйн улмаас, болгоогтун, тэд дэлхийн гадаргуу дээрээс арилгагдах болно.

16 Мөнхүү улиран тохиох дор би дайснуудынхаа эсрэг явахыг бүрнээ татгалзав; мөн бүр Их Эзэн надад зарлиг

болсончлон би үйлдэв; мөн ирэх зүйлсийн талаар гэрчилсэн Сүнсний үзүүлэлтүүдийн дагуу, би харсан мөн сонссон тэдгээр зүйлийг дэлхийд үзүүлэхээр оролцохгүй нэгэн гэрч болон зогссон бөлгөө.

17 Тиймийн тул би харийнхан “та нарт хандан бичиж байна, мөн түүнчлэн Израилын угсааныхан та нарт, уг ажил ундрахад, та нар өвийнхөө нутаг тийш буцаж очихоор бэлтгэхээр завдаж байх болно;

18 Тийм ээ, болгоогтун, дэлхийн бүх хязгааруудад; тийм ээ, Иерусалимын нутагт шавь нараа болгож Есүсийн сонгосон тэр арванхоёроор үйлүүдийн дагуу “шүүгдэж болох, Израилын арванхоёр овгийнхон та нарт хандан бичиж байна.

19 Мөн энэ хүмүүсийн үлдэгдэлд хандан түүнчлэн бичиж байна би, энэ нутагт Есүсийн сонгосон арванхоёроор түүнчлэн шүүгдэх тэдэнд; мөн тэд Иерусалимын нутагт Есүсийн сонгосон “арванхоёроор шүүгдэх болно.

20 Мөн эдгээр зүйлсийг Сүнс надад үзүүлж байна; тиймийн тул та бүгдэд бичиж байна би. Мөн энэ шалтгааны улмаас та нарт бичиж байна би, та нар бүгд Христийн “шүүлтийн суудлын өмнө зогсох ёстойгоо та нар, тийм

12а су Хайр.

б Морм. 5:2.

14а 3 Ниф. 12:34–37.

15а су Өс хонзон.

б С ба Г 82:23.

17а 2 Ниф. 30:3–8;

3 Ниф. 29:1.

18а Мат. 19:28;

Лук 22:29–30;

С ба Г 29:12.

19а 1 Ниф. 12:9–10.

20а су Эцсийн шүүлт.

ээ, Адамын хүмүүний бүх ^бгэр бүлд хамрагддаг бодгаль болгон мэдэж болохын тулд; мөн та нар өөрсдийн үйлүүдээр, тэдгээр нь сайн эсвээс хилэнцэт байлаа ч, шүүгдэхээр зогсох ёстой;

21 Мөн түүнчлэн та нарын дунд байх Есүс Христийн сайн мэдээнд та нар “итгэж болохын тулд; мөн түүнчлэн Их Эзэний гэрээт хүмүүс болох ^биудейчүүд, тэдний хөнөөсөн Есүсийг, ^вчухамхүү Христ мөн чухамхүү Бурхан хэмээн гэрчлэх, тэдний харсан мөн сонссон түүнээс өөр нэгэн ^ггэрчтэй байхын тулд буюу.

22 Мөн дэлхийн “бүх хязгаарууд та нар наманчилж мөн Христийн шүүлтийн суудлын өмнө зогсохоор бэлтгэхийг ятгаж чадаасай билээ би.

БҮЛЭГ 4

Дайн ба хядаан үргэлжлэв— Ёс бусыг үйлдэгчид ёс бусыг үйлдэгчдээ шийтгэнэ— Бүх Израилд урьд үзэгдээгүй илүү агуу ёс бус явдал тархав— Эмэгтэйчүүд мөн хүүхдүүд хиймэл шүтээнүүдэд золиослогдов— Леменчүүд нифайчуудыг өөрсдийнхөө өмнө хөөн, хөнөөж эхлэв. Ойролцоогоор мэ 363–375 он.

Мөнхүү эдүгээ улиран тохиох дор гурван зуун жаран гурав дахь онд нифайчууд леменчүүдийн эсрэг их цэрэгтэй-

гээ, Эзгүйрэлийн нутгаас гаран, тулалдахаар өгсөн одов.

2 Мөнхүү улиран тохиох дор нифайчуудын их цэрэг дахин Эзгүйрэлийн нутагт хүртэл ухраагдав. Мөн тэднийг туйлдсан хэвээр байхад нь, леменчүүдийн шинэхэн их цэрэг тэдэн дээр ирэв; мөн тэд ноцтой тулалдаанд орж, үүний хэрээр леменчүүд Эзгүйрэл хотыг эзэмшилдээ авч, мөн нифайчуудын олныг хөнөөн, мөн олон олзлогдогсдыг авсан бөлгөө.

3 Мөн үлдсэн нь зугтаж мөн Тианкум хотын оршин суугчидтай нэгдэв. Эдүгээ Тианкум хот тэнгисийн эргийн ойролцоо хилийн тэнд байх ажээ; мөн энэ нь түүнчлэн Эзгүйрэл хотын ойр байв.

4 Мөн нифайчуудын “их цэрэг леменчүүдийн өөдөөс явсан учир тэд цохигдож эхлэв; учир нь тэгээгүй байсан аваас, леменчүүд тэднийг давах хүчтэй байж чадахгүй байв.

5 Гэвч, болгоогтун, Бурханы шүүлтүүд ёс бусыг үйлдэгчдийг дийлэх болно; мөн ёс бусыг үйлдэгчдээр ёс бусыг үйлдэгчид нь “шийтгэгддэг; учир нь хүмүүний үрсийн зүрх сэтгэлийг цус урсгахад хүргэн өдөөн хатгадаг нь ёс бусыг үйлдэгчид юм.

6 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд Тианкум хотын эсрэг ирэх бэлтгэлээ базаав.

7 Мөнхүү улиран тохиох дор

20б С ба Г 27:11.

21а С ба Г 3:20.

б су Иудейчүүд.

в 2 Ниф. 25:18.

г 2 Ниф. 26:12;

Мозая 7:27.

22а Алма 29:1.

4 4а Морм. 3:10.

5а С ба Г 63:33.

гурван зуун жаран дөрөв дэх онд леменчүүд, тэд түүнчлэн Тианкум хотыг эзэмшилдээ авч болохын тулд, Тианкум хотын эсрэг ирэв.

8 Мөнхүү улиран тохиох дор тэд нифайчуудад ялагдан мөн ухрав. Мөн нифайчууд, тэд леменчүүдийг дахин буцааснаа хараад, тэд дахин өөрсдийн хүчинд сагсуурав; мөн тэд өөрсдийн хүчээр урагшилж, мөн Эзгүйрэл хотыг дахин эзэмшилдээ авсан ажгуу.

9 Мөн эдүгээ эдгээр бүх зүйлүүд үйлдэгдэж, мөн нифайчууд болон леменчүүдийн аль аль талд мянга мянга нь хөнөөгджээ.

10 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун жаран зургаан жил улиран одож, мөн леменчүүд нифайчуудын дээр тулалдахаар дахин ирэв; мөн нифайчууд өөрсдийн үйлдсэн хилэнцээс наманчлаагүй хэвээр байв, харин ёс бусын үйлээ үргэлжлүүлсээр байсан ажгуу.

11 Мөн хэлээр тайлбарлахад, эсвээс хүмүүнд нифайчууд мөн леменчүүд аль аль хүмүүсийн дунд байсан цус мөн хядааны аймшигт дүр зургийн төгс дүрслэлийг бичих нь боломжгүй юм; мөн зүрх сэтгэл болгон хатуурав, тиймээс тэд цус урсгахдаа байнга баясдаг байв.

12 Мөн Их Эзэний үгсийн дагуу, энэ хүмүүсийн дунд

байсан лугаа адил, тийм агуу “ёсон бусын үйл Лихайн бүх хүүхдүүдийн дунд ч, бас бүр Израилын бүх угсааны дунд ч байсангүй.

13 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд Эзгүйрэл хотыг эзэмшилдээ авч, мөн энэ нь тэдний “тоо нифайчуудын тоог давамгайлсны улмаас буюу.

14 Мөн тэд түүнчлэн Тианкум хотын эсрэг урагш давшиж, мөн оршин суугчдыг нь тэндээс хөөв, мөн эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийн алинаас олон олзлогдогсдыг авч, мөн тэднийг “хиймэл бурхаддаа тахил болгон өргөв.

15 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун жаран долоо дахь онд, леменчүүд тэдний эмэгтэйчүүд мөн тэдний хүүхдүүдийг золиосолсны улмаас, нифайчууд хилэгнэж, иймээс тэд агуу их хилэнтэйгээр леменчүүдийн эсрэг явж, үүний хэрээр тэд леменчүүдийг дахин дийлж, мөн тэднийг нутгаасаа үлдэн хөөв.

16 Мөн гурван зуун далан тав дахь он хүртэл леменчүүд нифайчуудын эсрэг дахин ирсэнгүй.

17 Мөн энэхүү онд тэд өөрсдийн бүх хүчээр нифайчуудын эсрэг дахин ирэв; мөн тэдний тооны агуу ихийн улмаас тэд тоологдоогүй буюу.

18 Мөн “энэ цагаас эхлэн нифайчууд леменчүүдийн дээгүүр хүч чадлыг олсонгүй,

12a Эхл. 6:5; 3 Ниф. 9:9.

13a Морм. 5:6.

14a су Хиймэл шүтээн.

18a Морм. 3:3.

харин нарны өмнөх шүүдэр лугаа адил тэднээр арчигдах болов.

19 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд дахин Эзгүйрэл хотын эсрэг уруудан ирэв; мөн Эзгүйрэл нутагт үлэмж ноцтой тулалдаан болж, түүнд тэд нифайчуудыг дийлэв.

20 Мөн тэд дахин тэдний өмнө зугтаж, мөн тэд Боазын хотод ирэв; мөн тэнд тэд үлэмж зоригтойгоор леменчүүдийн эсрэг зогсож, үүний хэрээр леменчүүд, тэд хоёр дахь удаагаа дахин ирэх хүртлээ тэднийг дийлсэнгүй.

21 Мөн тэднийг хоёр дахь удаагаа ирэхэд, нифайчууд хөөгдөн мөн үлэмж агуу аллагаар хүйс тэмтрүүлэв; тэдний эмэгтэйчүүд мөн тэдний хүүхдүүд дахин хиймэл шүтээнүүдэд золиослогдов.

22 Мөнхүү улиран тохиох дор нифайчууд дахин тэдний өмнө, хотод ч тосгодод ч байсан бүх оршин суугчдыг өөрсөдтэйгээ аван, зугтав.

23 Мөн эдүгээ би, Мормон, леменчүүд уг нутгийг сүйрүүлэх гэж буйг харсан учир, тиймийн тул би “Шим толгойд очин, мөн Их Эзэний төлөө Аммароны нуусан бүх цэдгүүдийг авав.

БҮЛЭГ 5

Мормон Нифайн их цэргийг цус мөн хядааны тулалдаанд дахин удирдав—Есүс бол Христ гэдэгт

бүх Израилыг үнэмшүүлэхээр Мормоны Ном гарч ирэх болно—Тэдний итгэлгүйн улмаас, леменчүүд тараагдаж, мөн Сүнс тэдний төлөө зүтгэхээ болих болно—Тэд хожмын өдрүүдэд харийнханаас сайн мэдээг хүлээн авах болно. Ойролцоогоор мэ 375–384 он.

Мөнхүү улиран тохиох дор би урагш нифайчуудын дунд явж, мөн би тэдэнд хойшид туслахгүй хэмээн үйлдсэн “тангаргаа наманчлав; мөн тэд дахин их цэргийнхээ удирдлагыг надад өгөв, учир нь тэд намайг зовлон зүдгүүрээс нь тэднийг чөлөөлж чадах мэтээр над өөд харж байв.

2 Гэвч болгоогтун, би “найдар үгүй байв, учир нь тэдний дээр ирэх Их Эзэний шүүлтүүдийг би мэдсэн юм; учир нь тэд алдсуудаа наманчилсангүй, харин өөрсдийг нь бүтээсэн Нэгэнийг дуудалгүйгээр амийнхаа төлөө тэмцсэн ажгуу.

3 Мөнхүү улиран тохиох дор бид Иорданы хот тийш зугтсан үед леменчүүд бидний эсрэг ирэв; гэвч болгоогтун, тэд ухрагдсанаас тэр үед тэд хотыг авсангүй.

4 Мөнхүү улиран тохиох дор тэд дахин бидний эсрэг ирж, мөн бид хотыг хадгалан хамгаалав. Мөн бидний нутгийн оршин суугчдыг устгахаар бидний өмнө орших нутаг тийш орж чадахгүй хэмээн тэднийг тусгаарласан бэхлэлтүүд болох, нифайчуудаар

хадгалагдан хамгаалагдсан өөр бусад хотууд байв.

5 Гэвч улиран тохиох дор бидний дайрч гарсан, мөн оршин суугчид нь цуглуулагдаагүй бүх нутгууд леменчүүдээр устгагдав, мөн тэдний суурингууд, мөн тосгод, мөн хотууд галд шатаагдав; мөн тийн гурван зуун далан есөн жил улирч одов.

6 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун ная дахь онд леменчүүд бидний эсрэг тулалдахаар дахин ирж, мөн бид тэдний эсрэг зоригтойгоор зогсов; гэвч энэ бүхэн бүгд хий хоосон байв, учир нь тэд нифайчуудыг хөл дороо дэвсэлсэн тэдний тоо тийм агуу байлаа.

7 Мөнхүү улиран тохиох дор бид дахин зугтаж, мөн гүйх нь леменчүүдийнхээс шаламгай байсан тэд амьд гарч, мөн леменчүүдийнхийг давж гараагүй тэд арчигдаж мөн устгагдав.

8 Мөн эдүгээ болгоогтун, би, Мормон, миний нүдний өмнө тавигдсан лугаа адил, цус мөн хядааны тийм аймшигт дүр зургийг тэдний өмнө гаргаснаар хүмүүсийн сэтгэлийг тарчилгахыг би үл хүснэ; гэвч эдгээр зүйлсүүд гарцаагүй мэдүүлэгдэх ёстой, мөн нуугдсан бүх зүйл байшингийн дээвар дээрээс “илчлэгдэх ёстойг би мэдэх учир —

9 Мөн түүнчлэн эдгээр

зүйлсийн мэдлэг нь эдгээр хүмүүсийн үлдэгдэлд, мөн түүнчлэн энэ хүмүүсийг “тараана хэмээн, мөн энэ хүмүүс тэдний дунд хэн ч хэмээн үл тооцогдоно хэмээн Их Эзэн хэлсэн харийнханд ⁶ирэх ёстойг — тиймийн тул, би хүлээн авсан зарлигийнхаа улмаас, өөрийн харсан тэр зүйлсийн бүрэн шастирыг өгөхийг үл зүрхлэхийн учир, мөн түүнчлэн энэ хүмүүсийн ёс бус үйлээс болж та нар дэндүү их харуусалтай байхгүйн тулд би нэгэн “богино хураангуйллыг бичье.

10 Мөн эдүгээ болгоогтун, үүнийг би тэдний үрсэд, мөн түүнчлэн Израилын угсаанд санаа тавих, адислалууд нь хаанаас ирдгийг ухаарч мөн мэдэх харийнханд ярьж байна.

11 Тийм нь Израилын угсааны гай гамшгийн улмаас харуусахыг би мэдэхийн учир буюу; тийм ээ, тэд энэ хүмүүсийн устгалын төлөө харуусах болно; тэд Есүсийн мутарт тэврэгдэж болохын тулд энэ хүмүүс наманчилсангүйд тэд харуусах болно.

12 Эдүгээ “эдгээр зүйлс нь Иаковын угсааны ⁶үлдэгдэлд бичигдсэн бөлгөө; мөн ёс бус байдал нь тэдгээрийг урагш тэдэнд авчрахгүй нь Бурханд мэдэгддэгийн улмаас, тэдгээр нь энэ маягаар бичиглэгдсэн буюу; мөн тэдгээр нь түүний зохих цагт урагш ирж

8а Лук 12:2–3;
2 Ниф. 27:11;
С ба Г 1:3.
9а 3 Ниф. 16:8.

б 4 Ниф. 1:49.
в Морм. 1:1.
12а Инос 1:16;
Хил. 15:11–13.

су Мормоны Ном.
б С ба Г 3:16–20.

болохын тулд Их Эзэний төлөө ^адалдлагдах ёстой.

13 Мөн миний хүлээн авсан зарлиг энэ болой; мөн болгоогтун, Их Эзэний зарлигийн дагуу, тэрбээр өөрийн мэргэн ухаанд нийцнэ хэмээн үзэх үед, тэдгээр нь гарч ирэх болно.

14 Мөн болгоогтун, тэдгээр нь “иудейчүүдийн үл итгэх тэдэнд очих болно; мөн энэ зорилгын учир тэдгээр нь очих болно— тэд, Есүс бол Христ, амьд Бурханы Хүү гэдэгт ^ятгуулагдаж болохын тул; өөрийн хамгийн Хайртаар дамжуулан, өөрийн ^гтэрээг биелүүлэн, Их Эзэн тэдний Бурхан тэдэнд соёрхсон, тэдний өвийн нутагт иудейчүүдийг, эсвээс Израилын бүх угсааг сэргээснээр, Эцэг өөрийн агуу хийгээд мөнхийн зорилгыг биелүүлж болохын тулд болой;

15 Мөн түүнчлэн, харийнханаас тэдэнд ^оочих түүний сайн мэдээнд ^бэнэ хүмүүсийн үрс илүү бүрнээр итгэж болохын тулд буюу; учир нь энэ хүмүүс ^атараагдаж, мөн бидний дунд байсан түүний ямар ч дүрслэлээс, тийм ээ, бүр леменчүүдийн дунд байснаас ч илүүгээр ^вхаранхуй, зэвүүцэм, мөн буртаглагдсан хүмүүс болох болно, мөн энэ нь тэдний итгэлгүй байдал

болоод хиймэл шүтээн шүтдэгийн улмаас буюу.

16 Учир нь болгоогтун, Их Эзэний Сүнс тэдний эцэг дээдсийн төлөө ^азүтгэхээ аль хэдийн больсон ажгуу; мөн тэд дэлхийд Христ болон Бурхангүйгээр байгаа болой; мөн тэд салхинд туугдах ^ббудааны хальс лугаа адил хөөгдөж байгаа билээ.

17 Тэд нэгэн цагт бахдам сайхан хүмүүс байв, мөн тэд Христийг өөрсдийн “хоньчин болгосон байв; тийм ээ, тэд бүр Бурхан Эцэгээр удирдуулдаг байв.

18 Гэвч эдүгээ, болгоогтун, тэд Сатанаар, бүр салхинд туугдах будааны хальс лугаа адил, эсвээс далбаа эс бөгөөс зангуугүй, эс бөгөөс түүнийг жолоодох юу ч үгүйгээр давалгаан дээр шидэгдэх хөлөг лугаа адил ^ахөтлүүлж байгаа бөлгөө; мөн бүр тэд түүний адилаар байгаа болой.

19 Мөн болгоогтун, тэд уг нутагт хүлээн авч болох байсан тэдгээр адислалуудыг уг нутгийг эзэмших учиртай ^ахарийнханы улмаас Их Эзэн хадгалсан бөлгөө.

20 Гэвч болгоогтун, улиран тохиох дор тэд харийнханаар хөөгдөж мөн тараагдах болно; мөн тэд харийнханаар хөөгдөж мөн тараагдсаны дараа, болгоогтун, тэгээд Их

12в Морм. 8:4, 13–14;
Моро. 10:1–2.

14а 2 Ниф. 29:13; 30:7–8.
су Иудейчүүд.
б 2 Ниф. 25:16–17.
в 3 Ниф. 29:1–3.

15а 3 Ниф. 21:3–7, 24–26.
б 1 Ниф. 13:20–29, 38;
Морм. 7:8–9.
в 1 Ниф. 10:12–14;
3 Ниф. 16:8.
г 2 Ниф. 26:33.

16а Эхл. 6:3; Ифер 2:15.
б Дуул. 1:4.
17а су Сайн Хоньчин.
18а 2 Ниф. 28:21.
19а 3 Ниф. 20:27–28.

Эзэн, Абрахамд мөн Израилын бүх угсаанд хийсэн “гэрээгээ” санах болно.

21 Мөн түүнчлэн Их Эзэн тэдний төлөө түүнд өргөгдсөн зөв шударгыг үйлдэгчдийн “залбирлуудыг санах болно.

22 Мөн тэгвэл, Ай Харийнхан та нар, та нар наманчилж хилэнцэт замаасаа эргэхээс бусдаар, Бурханы хүчний өмнө хэрхэн зогсож чадах билээ?

23 Бурханы мутарт гэдгээ та нар мэдэхгүй гэж үү? Тэрбээр бүх хүчийг эзэмшдэг, мөн түүний агуу “удирдлагаар газар дэлхий хуйлмал бичиг лугаа адил” хуйлагдах болно гэдгийг та нар мэдэхгүй гэж үү?

24 Тиймийн тул, наманчлагтун та нар, мөн шударга ёсонд тэрбээр та нарын эсрэг ирэх вий хэмээн — Иаковын үрийн нэгэн үлдэгдэл та нарын дунд “арслан лугаа адил явж, мөн та нарыг хэдэн хэсэг тасчин, мөн чөлөөлөх хэн ч үгүй байх болуузай хэмээн түүний өмнө өөрсдийгөө даруусга.

БҮЛЭГ 6

Эцсийн тулалдаануудын төлөө нифайчууд Куморагийн нутагт цугларав—Мормон ариун нандин цэдгүүдийг Куморагийн гүвээнд нуув—Леменчүүд ялагч

байж, мөн Нифайн үндэстэн устгагдав—Зуу зуун мянга нь илдэнд хөнөөгдөв. Ойролцоогоор мэ 385 он.

Мөн эдүгээ өөрийн хүмүүс, нифайчуудын “устгалын талаарх цэдгээ би өндөрлөө. Мөнхүү улиран тохиох дор бид леменчүүдийн өмнө урагш жагсан одсон буюу.

2 Мөн би, Мормон, леменчүүдийн хаанд захидал бичиж, мөн бид өөрсдийн хүмүүсийг Кумора хэмээн нэрлэгдэх гүвээний ойр, Куморагийн “нутагт цуглуулахыг бидэнд зөвшөөрөхийг түүнээс хүсэмжлэн, мөн тэнд бид тэдэнтэй тулалдаанд орохыг хэлэв.

3 Мөнхүү улиран тохиох дор миний хүсэмжилсэн түүнийг леменчүүдийн хаан надад зөвшөөрсөн бөлгөө.

4 Мөнхүү улиран тохиох дор бид Куморагийн нутаг хүртэл жагсан очиж, мөн бид Кумора гүвээний эргэн тойронд бид майхнуудаа босгов; мөн энэ нь олон ус, мөн голууд, мөн усан оргилууд бүхий нутаг байв; мөн энд бид леменчүүдийн дээгүүр давамгай байдлыг олж авна хэмээн найдаж байв.

5 Мөн гурван зуун наян дөрвөн жил улирч одоход, бид өөрсдийн хүмүүсийн үлдэгдлийг бүгдийг Куморагийн нутагт цуглуулав.

20a су Абрахамын гэрээ.

б 3 Ниф. 16:8–12.

21a Инос 1:12–18;

Морм. 9:36–37.

23a Хил. 12:8–17.

б 3 Ниф. 26:3.

24a Мика 5:8;

3 Ниф. 20:15–16.

6 1a 1 Ниф. 12:19;

Жером 1:10;

Алма 45:9–14;

Хил. 13:5–11.

2a Ифер 9:3.

6 Мөнхүү улиран тохиох дор бид бүх хүмүүсээ нэгтгэн, Куморагийн нутагт цуглуулсны дараа, болгоогтун би, Мормон, нас өндөр болж эхлэв; мөн энэ нь миний хүмүүсийн сүүлчийн тулалдаан болохыг мэдсэн учир, мөн манай эцэг дээдсээр доош гардуулагдан дамжуулагдсан, ариун нандин болох эл цэдгүүдийг леменчүүдийн гарт орохыг эс хүлцэхийг би Их Эзэнээр зарлиг болгуулсан учир, (леменчүүд тэдгээрийг устгахын учир) тиймийн тул би “энэхүү цэдгийг Нифайн ялтсуудаас үйлдэж, мөн би хүү ⁶Моронайдаа өгсөн “эдгээр цөөн хэдэн ялтсаас бусад, Их Эзэний мутраар надад итгэмжлэгдсэн бүх цэдгүүдийг Кумора гүвээнд ⁷нуув.

7 Мөнхүү улиран тохиох дор миний хүмүүс, өөрсдийн эхнэр мөн өөрсдийн хүүхдүүдийн хамт, эдүгээ леменчүүдийн “их цэргийг өөрсдийн зүг давшихыг харж байв; мөн ёс бус бүгдийн цээжийг дүүргэх үхлийн аюумшигт айдастайгаар, тэднийг хүлээн авахаар тэд хүлээж байв.

8 Мөнхүү улиран тохиох дор тэд бидний эсрэг тулалдахаар ирж, мөн тэдний тооны агуугийн улмаас бодгаль бүр айдсаар дүүрсэн байв.

9 Мөнхүү улиран тохиох дор тэд миний хүмүүс дээр илдтэйгээр, мөн нум, мөн сум,

мөн сүх, мөн бүх л төрлийн дайны зэвсэгтэйгээр буун ирэв ээ.

10 Мөнхүү улиран тохиох дор миний эрчүүд хиар цохигдож, тийм ээ, бүр надтай хамт байсан миний арван мянга, мөн би дунд нь шархдан унасан буюу; мөн тэд намайг өнгөрөн явснаас амийг минь төгсгөл болгосонгүй.

11 Мөн бидний хорин дөрвөөс (дунд нь миний хүү Моронай байв) бусад миний “бүх хүмүүсийг тэд дайран гараад мөн хиар цохьсны дараа, мөн бид өөрсдийн хүмүүсийн үхэгсдийн ард амь гарч үлдсэний дараа, леменчүүд буудалласан газартаа буцахад, маргааш өдөр нь урьд нь надаар удирдуулж асан хүмүүсийнхээ хиар цохиулсан арван мянгыг бид Кумора гүвээний оройгоос болгоов.

12 Мөн бид түүнчлэн миний хүү Моронайгаар удирдуулсан арван мянгыг болгоосон буюу.

13 Мөн болгоогтун, Гидгиддонайн арван мянга, мөн тэрбээр дунд нь унасан байв.

14 Мөн Лама мөн өөрийн арван мянгатай унажээ; мөн Гилгал өөрийн арван мянгатай унажээ; мөн Лимха өөрийн арван мянгатай унаж; мөн Жениам өөрийн арван мянгатай унасан байв; мөн Кюмениха, мөн Моронайха, мөн Антионум, мөн Шиблом, мөн Шем, мөн Жош тус

6а су Ялтсууд.
б Морм. 8:1.
в Мор. үгс 1:2.

г Ифер 15:11.
7а 1 Ниф. 12:15.
11а 1 Ниф. 12:19–20;

Хил. 15:17.

бүрийн арван мянгатай унасан ажгуу.

15 Мөнхүү улиран тохиох дор өөр өөрсдийн арван мянгын хамт, илдэнд унасан өөр арав байв; тийм ээ, надтай хамт байсан тэдгээр хорин дөрөв, мөн түүнчлэн өмнөд нутгуудын зүг дүрвэсэн цөөн хэд, мөн леменчүүдэд урвасан цөөн хэдээс бусад нь бүр миний “бүх хүмүүс унажээ; мөн уг нутагт ялзраан, мөн үйрүүлж бутраан мөн эх дэлхийд нь буцаахаар тэднийг хиаруулсан тэдний гараар орхигдсон учир тэдний цогцос, яс, мөн цус дэлхийн гадаргуу дээр хэвтэж байв.

16 Мөн бодгаль минь, хүмүүсийнхээ хөнөөгдсөний улмаас, зовлондоо урагдаж, мөн хашгирав би:

17 Ай хонгорхон та нар, та нар Их Эзэний замаас яахин салж чадаваа! Ай хонгорхон та нар, та нарыг хүлээн авахаар гараа дэлгэн зогссон, Есүсээс та нар хэрхэн татгалзаж чадав аа!

18 Болгоогтун, хэрэв та нар үүнийг эс үйлдсэн аваас, та нар унахгүй байсан. Гэвч болгоогтун, та нар унасан, мөн та нарыг алдсандаа га шууднам би.

19 Ай хонгорхон хөвгүүд, охид та нар, эцгүүд мөн эхчүүд та нар, мөн нөхрүүд хийгээд эхнэрүүд та нар, хонгорхон та нар, хэрхэн унаж чадаваа та нар!

20 Гэвч болгоогтун, та нар

үгүй болсон, мөн миний харууслууд та нарыг эргүүлж авчирч эс чадна.

21 Мөн та нарын зуурдын байдал үхэшгүйд тавигдана, мөн эдүгээ ялзралдаа муудаж буй эдгээр цогцсууд удахгүй “ялзаршгүй цогцос болох ёстой тэр өдөр удахгүй ирнэ; мөн тэгээд та нар Христийн шүүлтийн суудлын өмнө, үйлүүдийнхээ дагуу шүүгдэхээр зогсох ёстой; мөн хэрэв та нар зөв шударга байсан аваас, тэгвэл та нар өөрсдийн тань өмнө одсон эцэг дээдэстэйгээ хамт адислагдах болно.

22 Ай та нар энэхүү агуу устгал та нарын дээр ирэхийн өмнө наманчилсан ч болоосой. Гэвч болгоогтун, та нар үгүй болсон, мөн Эцэг, тийм ээ, тэнгэрийн Мөнхийн Эцэг та нарын байдлыг мэднэ; мөн тэрбээр өөрийн “шударга ёс хийгээд” нигүүлслийн дагуу та нарт үйлддэг бөлгөө.

БҮЛЭГ 7

Мормон хожмын үеийн леменчүүдийг Христэд итгэж, түүний сайн мэдээг хүлээн зөвшөөрч, мөн аврагдахыг урив—Библид итгэдэг хэн бүхэн түүнчлэн Мормоны Номонд итгэх болно. Ойролцоогоор мэ 385 он.

Мөн эдүгээ, болгоогтун, тэд өөрсдийн эцэг дээдсийн зүйлсийг мэдэж болохын тулд,

хэрэв Бурхан миний үгсийг тэдэнд өгөх аваас, энэ хүмүүсийн хэлтрүүлэгдсэн “үлдэгдэлд би заримыг ярихыг хүснэ; тийм ээ, би та нарт, Израилын угсааны үлдэгдэл та нарт ярьж байна; мөн миний ярих үгс нь эдгээр буюу:

2 Та нар Израилын “угсааных гэдгээ мэдэгтүн, та нар.

3 Та нар наманчлалд ирэх ёстой, эсвээс та нар аврагдаж чадахгүйгээ мэдэгтүн, та нар.

4 Та нар дайны зэр зэвсгүүдээ хаяж, мөн цус урсгахад цаашид сэтгэл үл хөөрч, мөн Бурхан та нарт зарлиглахаас бусдаар, тэдгээрийг дахин үл авах ёстойгоо мэдэгтүн, та нар.

5 Та нар өөрсдийн эцэг дээдсийн “мэдлэгт ирж, мөн өөрсдийн бүх нүглүүд мөн алдсуудаас наманчилж, мөн Есүс Христэд, тэрбээр Бурханы Хүү, мөн тэрбээр иудейчүүдээр хөнөөгдсөн, мөн Эцэгийн хүчээр тэрбээр дахин боссон, тэгснээр тэрбээр булшны дээгүүр ^бялалт олсон; мөн түүнчлэн үхлийн шаналал түүнд залгигдсан гэдэгт ^аитгэх ёстойгоо мэдэгтүн, та нар.

6 Мөн тэрбээр нас барагсдын “амилуулалтыг улируулан

тохиолгож, тэгснээр хүмүүн түүний ^бшүүлтийн суудлын өмнө зогсохоор босгогдоно гэдэгт.

7 Мөн дэлхийн “гэтэлгэлийг тэрбээр улируулан тохиолгосон, тэгснээр шүүлтийн өдөр түүний өмнө ^бгэмгүй нь тогтоогдсон тэрэнд, дээдхийн “найралд эцэсгүй магтууг ‘нэг Бурхан болох, Эцэгт, мөн Хүүд, мөн Ариун Сүнсэнд, эцэсгүй ^ааз жаргалтай байдлаар дуулахаар түүний хаант улсад Бурханы ^ддэргэд амьдрах нь өгөгдөнө гэдэгт буюу.

8 Тиймийн тул наманчлагтун, мөн Есүсийн нэрээр баптисм хүртэгтүн, мөн зөвхөн энэ цэдгээр бус харин түүнчлэн “иудейчүүдээс харийнханд ирэх, харийнханаас ^бта нарт ирэх тэр ^ццэдгээр та нарын өмнө тавигдах Христийн ^ссайн мэдээнээс баригтун.

9 Учир нь болгоогтун, “энэ нь та нар түүнд ^битгэж болно хэмээх зорилготойгоор бичигдсэн юм; мөн хэрэв та нар түүнд итгэх аваас та нар түүнчлэн үүнд итгэх болно; мөн хэрэв та нар үүнд итгэх аваас та нар өөрсдийн эцэг дээдсийн талаар, мөн түүнчлэн тэдний дунд Бурханы хүчээр үйлдэгдсэн

7 1а Хил. 15:11–13.

2а Алма 10:3.

5а 2 Ниф. 3:12.

б Иса. 25:8;

Мозая 16:7–8.

в су Итгэлтэй байх,

Итгэл; Итгэл.

6а су Амилуулалт.

б су Есүс Христ—

Шүүгч; Эцсийн

шүүлт.

7а су Гэтэлгэх,

Гэтэлгэгдэх,

Гэтэлгэл.

б су Зөвтгөл,

Зөвтгөх.

в Мозая 2:28.

г С ба Г 20:28.

су Бурхан, Бурхан

тэргүүтэн.

д су Баяр баясгалан.

е 1 Ниф. 10:21;

С ба Г 76:62;

Моце 6:57.

8а 2 Ниф. 29:4–13.

б 1 Ниф. 13:38.

в су Библи.

г су Сайн Мэдээ.

9а су Мормоны Ном.

б 1 Ниф. 13:38–41.

гайхамшигт үйлүүдийн талаар та нар мэдэх болно.

10 Мөн та нар Иаковын үрийн нэгэн үлдэгдэл болохоо та нар түүнчлэн мэдэх болно; тиймийн тул та нар анхны гэрээт хүмүүсийн дунд тоологдох буюу; мөн хэрэв та нар Христэд итгэн, мөн бидний Аврагчийн “жишээг даган, тэрээр бидэнд зарлиг болгосны дагуу, эхлээд усаар, дараа нь галаар мөн Ариун Сүнсээр баптисм хүртэх аваас, шүүлтийн өдөр та нарын хувьд сайн байх болно. Амен.

БҮЛЭГ 8

Леменчүүд нифайчуудыг хайж мөн устгав—Мормоны Ном Бурханы хүчээр гарч ирэх болно—Их Эзэний ажлын эсрэг хилэгнэлийг мөн хэрүүл маргааныг ярих тэдний дээр халаг зарлагдав—Нифай үндэстний цэдэг ёс бус явдал, доройтол, мөн урвалтын үед гарч ирэх болно. Ойролцоогоор мэ 400–421 он.

Болгоогтун Моронай, би, өөрийн эцэг “Мормоны ^бцэдгийг дуусгая. Болгоогтун, би эцгээрээ зарлиг болгуулсан, бичих зөвхөн хэдхэн зүйлс надад буй.

2 Мөнхүү улиран тохиох дор Кумора дахь “агуу мөн нүсэр тулалдааны дараа, болгоогтун, өмнө зүгийн нутаг тийш

дүрвэсэн нифайчууд ^блеменчүүдээр, тэд бүгд устгагдах хүртлээ мөрдөгдсөн болой.

3 Мөн миний эцэг бас тэднээр хөнөөгдсөн буюу, мөн би өөрийн хүмүүсийн устгалын энэхүү гунигт түүхийг бичихээр бүр “ганцаар амьд үлдсэн бөлгөө. Гэвч болгоогтун, тэд үгүй болсон, мөн би эцгийнхээ зарлигийг биелүүлнэ. Мөн тэд намайг хөнөөх эсэхийг би үл мэднэ.

4 Тиймийн тул би уг цэдгүүдийг бичиж мөн газарт нуух болно; мөн миний хааш явах нь хамаагүй.

5 Болгоогтун, миний эцэг “энэ цэдгийг бүтээж, мөн тэрбээр үүний учир шалтгааныг бичсэн болой. Мөн болгоогтун, хэрэв надад уг ^бялтсууд дээр зай байсан аваас би үүнийг түүнчлэн бичих байв, гэвч надад байхгүй; мөн би ганцаараа учир, надад хүдэр үгүй. Миний эцэг, мөн миний бүх төрөл садан тулалдаанд хөнөөгдсөн, мөн би найз нөхөдгүй мөн явах газаргүй боллоо; мөн намайг хэр удаан амьдарч болно хэмээн Их Эзэн зөвшөөрөхийг би мэдэхгүй.

6 Болгоогтун, бидний Их Эзэн мөн Аврагчийн ирэлтээс хойш дөрвөн “зуун жил улиран оджээ.

7 Мөн болгоогтун, леменчүүд миний хүмүүс, нифайчуудыг, хотоос хотод мөн

10a 2 Ниф. 31:5–9.
8 1a су Моронай,
Мормоны хүү.
б су Ялтсууд.

2a Морм. 6:2–15.
б С ба Г 3:18.
3a Моро. 9:22.
5a Морм. 2:17–18.

б Морм. 6:6.
6a Алма 45:10.

газраас газарт, бүр тэднийг үгүй болтол нь мөрдөв; мөн тэдний “уналт агуу байв; тийм ээ, миний хүмүүс, нифайчуудын устгал агуу хийгээд гайхмаар байлаа.

8 Мөн болгоогтун, үүнийг үйлдсэн нь Их Эзэний мутар юм. Мөн түүнчлэн болгоогтун, леменчүүд нэг нэгэнтэйгээ “даинд оржээ; мөн энэ нутгийн бүх гадаргуу үргэлжийн аллага хийгээд цус урсгалтын талбар болов; мөн дайны төгсгөлийг хэн ч үл мэднэ.

9 Мөн эдүгээ, болгоогтун, тэдний талаар би илүүг үл дурдана, учир нь уг нутгийн гадаргуу дээр леменчүүд мөн “дээрэмчдээс өөр орших хэн ч үгүй бөлгөө.

10 Мөн Их Эзэн тэднийг хүмүүстэй “үлдэхийг эс зөвшөөрсөн аж, хүмүүсийн ёс бус нь тийм агуу болтол уг нутагт үлдсэн ажгуу, Есүсийн ^бшавь нараас бусад нь бол үнэн Бурханыг мэдэх нэгэн ч үгүй; мөн тэднийг уг нутгийн гадаргуу дээр буй эсэхийг нэг ч хүмүүн эс мэдэх бөлгөө.

11 Гэвч болгоогтун, миний “эцэг мөн би тэднийг харсан, мөн тэд бидэнд тохинуулсан болой.

12 Мөн энэ цэдгийг хүлээн авсан, мөн үүнд буй төгс бусаас болж үүнийг үл буруушаах хэн боловч, мөнхүү

тэр нь эдгээрээс “илүү агуу зүйлсийг мэдэх болно. Болгоогтун, би бол Моронай; мөн боломжтой байсан бол, би бүх зүйлсийг та нарт мэдүүлэхсэн.

13 Болгоогтун, энэ хүмүүсийн талаар ярихаа төгсгөл болгоё би. Би бол Мормоны хүү, мөн миний эцэг Нифайн “удам байсан болой.

14 Мөн би бол энэ цэдгийг Их Эзэний төлөө “нуух мөнхүү тэр буюу; Их Эзэний зарлигийн улмаас, үүний ялтсууд үнэгүй юм. Учир нь ^бэд хөрөнгө олохын тулд үүнийг хэн ч эс эзэмших болно хэмээн тэрбээр үнэнээр хэлдэг бөлгөө; гэвч үүний цэдэг агуу үнэтэй юм; мөн үүнийг гэрэлд авчрах, түүнийг Их Эзэн адислах болно.

15 Учир нь Бурханаас өгөгдсөнөөр бус аваас үүнийг гэрэлд авчрах хүчийг хэн ч агуулж чадах нь үгүй; учир нь энэ нь түүний алдар суугийн, эсвээс эртний мөн тархаад удсан Их Эзэний гэрээт хүмүүсийн аз жаргалын тулд “бүхнээ зориулах учиртай хэмээн Бурхан хүсэх ажгуу.

16 Мөн энэ зүйлийг гэрэлд авчрах “тэр нь адислагдах болно; учир нь энэ нь Бурханы үгийн дагуу харанхуйгаас гэрэлд ^бавчрагдах болно; тийм ээ, энэ нь газраас

7а 1 Ниф. 12:2–3.
8а 1 Ниф. 12:20–23.
9а Морм. 2:8.
10а Морм. 1:16.
б 3 Ниф. 28:7;
Ифр 12:17.

су Нифайчуудын
гурван шавь.
11а 3 Ниф. 28:24–26.
12а 3 Ниф. 26:6–11.
13а 3 Ниф. 5:20.
14а Моро. 10:1–2.

б ИС—Т 1:46.
15а С ба Г 4:5.
16а 2 Ниф. 3:6–7, 11,
13–14.
б Иса. 29:18;
2 Ниф. 27:29.

гаргагдан авчрагдаж, мөн энэ нь харанхуйгаас гэрэлтэж, мөн хүмүүсийн мэдлэгт ирэх болно; мөн энэ нь Бурханы хүчээр үйлдэгдэх болно.

17 Мөн хэрэв “алдаанууд байх аваас тэдгээр нь хүмүүний алдаанууд бөлгөө. Гэвч болгоогтун, бид ямар ч алдааг эс мэднэ; гэсэн хэдий ч Бурхан бүх зүйлийг мэддэг; тиймийн тул, ^ббуруушаах, тэрбээр тамын галын аюулд орох болуузай хэмээн сэрэмжлэг.

18 Мөн: Надад үзүүлэгтүн, эсвээс та цохигдоно хэмээн хэлэх тэр нь — тэрбээр Их Эзэнээр хориглогдсон түүнийг зарлиглах болуузай хэмээн сэрэмжлэг.

19 Учир нь болгоогтун, өнгөцхөн “шүүх мөнхүү тэр, хариуд нь өнгөцөөр шүүгдэх болно; учир нь түүний ажлуудын дагуу л түүний хөлс бодогдоно; тиймийн тул, цохих тэр, хариуд нь Их Эзэнээр цохигдох болно.

20 Судрын хэлж буйг болгоогтун — хүмүүн цохих учиргүй, бас тэрбээр шүүх ч ёсгүй; учир нь шүүлт бол минийх, мөн өшөө авалт түүнчлэн минийх, мөн би хариу төлнө хэмээн Их Эзэн хэлдэг.

21 Мөн Их Эзэний ажлын эсрэг, мөн Израилын угсаа болох Их Эзэний гэрээт хүмүүсийн эсрэг хилэгнэл хийгээд хэрүүл маргааныг

ярьдаг, мөн: Бид Их Эзэний ажлыг устгана, мөн Их Эзэн Израилын угсаатай хийсэн гэрээгээ санадаггүй хэмээн хэлдэг тэрээр — мөнхүү тэр нь цавчигдаж мөн галд хаягдах аюулд буй;

22 Учир нь Их Эзэний мөнхийн “зорилгууд, түүний бүх амлалтууд биелэгдэх хүртэл үргэлжилсээр байх болно.

23 “Исаиагийн бошиглолудыг судал. Болгоогтун, би тэдгээрийг бичиж үл чадна. Тийм ээ, болгоогтун, би та нарт хэлнэ, миний өмнө одсон, энэ нутгийг эзэмшиж асан тэдгээр гэгээнтнүүд ^бзалбиран гуйх болно, тийм ээ, бүр шорооноос тэд Их Эзэнд хандан залбиран гуйх болно; мөн Их Эзэн амьдын адил тэрбээр тэдэнтэй байгуулсан гэрээгээ санах болно.

24 Мөн тэрбээр тэдний “залбирлуудыг, тэдгээр нь тэдний ахан дүүсийн төлөө байсныг мэддэг. Мөн тэрбээр тэдний итгэлийг мэддэг, учир нь түүний нэрээр тэд ^буулыг зайлуулж чадсан юм; мөн түүний нэрээр тэд газар дэлхийг чичиргэж чадсан юм; мөн түүний үгийн хүчээр тэд ^бшоронгуудыг газарт нурах болгосон билээ; тийм ээ, бүр галт зуух ч, бас зэрлэг араатнууд ч, хорт могойнууд ч тэднийг гэмтээж чадаагүй юм.

25 Мөн болгоогтун, тэдний

17a Морм. 9:31, 33;
Ифер 12:23–28.
б 3 Ниф. 29:5;
Ифер 4:8.
19a исо, Мат. 7:1–2;
3 Ниф. 14:1–2;

Моро. 7:14.
22a С ба Г 3:3.
23a 3 Ниф. 20:11; 23:1.
б Иса. 29:4;
2 Ниф. 3:19–20; 26:16.
24a Инос 1:12–18;

Морм. 9:36;
С ба Г 10:46.
б Иаков 4:6; Хил. 10:9.
в Алма 14:27–29.

“залбирлууд түүнчлэн эдгээр зүйлсийг авчрахыг нь Их Эзэн зөвшөөрөх түүний төлөө байсан юм.

26 Мөн тэд үл ирнэ хэмээн хэн ч хэлэх хэрэггүй, учир нь тэд гарцаагүй ирэх болно, учир нь Их Эзэн үүнийг хэлсэн билээ; учир нь тэд “газраас Их Эзэний мутраар гарч ирэх болно, мөн хэн ч үүнийг зогсоож чадахгүй; мөн ^бгайхамшгууд зогссон хэмээн хэлэгдэх тэр өдөр энэ нь ирэх буюу; мөн энэ нь бүр хэн нэгэн “нас барагсдын дундаас ярих лугаа адил ирэх болно.

27 Мөн “нууц хуйвалдаанууд мөн харанхуйн ажлуудын улмаас, гэгээнтнүүдийн ^бцус Их Эзэнд хандан залбиран гуйх тэр өдөр энэ нь ирнэ.

28 Тийм ээ, энэ нь Их Эзэний хүч үгүйсгэгдэж, мөн “сүмүүд бузарлагдах болж, мөн тэд зүрх сэтгэлийн бардамналдаа өргөгдөх тэр өдөр; тийм ээ, бүр сүмүүдийн удирдагчид хийгээд багш нар бүр өөрсдийн сүмд харьяалагдах тэдэнд атаархах хүртлээ зүрх сэтгэлийн бардамналдаа хөөрөх тэр өдөр ирнэ.

29 Тийм ээ, харь нутгуудад, гал түймэр, мөн догшин шуурга, мөн “хөшиглөх

утааны талаар ^бсонсогдох тэр өдөр энэ нь ирнэ.

30 Мөн түүнчлэн “дайнүүд, дайны цуурхлууд, мөн хаа сайгүй газар хөдлөлтүүдийн талаар сонсогдох болно.

31 Тийм ээ, энэ нь дэлхийн гадаргуу дээр агуу бохирдол байх тэр өдөр ирнэ; аллага, мөн дээрэм, мөн худал үг, мөн заль мэх, мөн садар самуун, мөн бүх төрлийн жигшүүрт хэргүүд байх болно; Үүнийг хий, эсвээс түүнийг хий, мөн Их Эзэн тиймэрхүү нэгнийг эцсийн өдөр “дэмжих учир, энэ нь ^бхамаагүй хэмээн хэлэх нь олон байх тэр үед буюу. Гэвч тиймэрхүү нэгэнд халаг, учир нь тэд “шаналлын гүн болон алдсын хүлээст буй.

32 Тийм ээ, энэ нь: Надад ирэгтүн, мөн мөнгөнийхөө учир та нүглээсээ өршөөгдөх болно хэмээн хэлэх сүмүүд байгуулагдах тэр өдөр ирнэ.

33 Ай ёс бус мөн тэрс мөн гөжүүд хүмүүс та нар, яагаад та нар “ашиг олохын тулд өөрсдөдөө сүмүүдийг байгуулсан юм бэ? Яагаад та нар өөрсдийн бодгаль дээр ^бял авчирч болохын учир, Бурханы ариун үгийг “хувиргасан бэ? Болгоогтун, Бурханы

25a Морм. 5:21.

26a Иса. 29:4;

2 Ниф. 33:13.

б Морм. 9:15–26;

Моро. 7:27–29, 33–37.

в 2 Ниф. 26:15–16;

Морм. 9:30;

Моро. 10:27.

27a су Нууц

хуйвалдаанууд.

б Ифер 8:22–24;

С ба Г 87:6–7.

28a 2 Тиа. 3:1–7;

1 Ниф. 14:9–10;

2 Ниф. 28:3–32;

С ба Г 33:4.

29a 1 Ниф. 19:11;

С ба Г 45:39–42.

б Иоел 2:28–32;

2 Ниф. 27:2–3.

30a Мат. 24:6;

1 Ниф. 14:15–17.

31a 2 Ниф. 28:8.

б 2 Ниф. 28:21–22.

в Алма 41:11.

33a су Санваараар мэргэших.

б су Ял.

в 1 Ниф. 13:26–29.

илчлэлтүүд өөд харагтун, та нар; учир нь болгоогтун, тэр өдөр эдгээр бүх зүйлс биелэгдэх ёстой тэр цаг ирэх болно.

34 Болгоогтун, та нарын дунд эдгээр зүйлс гарч ирэх тэр өдөр, удахгүй ирэх ёстой түүний талаар Их Эзэн надад агуу хийгээд гайхамшигт зүйлийг үзүүлсэн болой.

35 Болгоогтун, хэдийгээр та нар үгүй ч, та нар өмнө минь буй мэтээр би та нартай ярьж байна. Гэвч болгоогтун, Есүс Христ та нарыг надад үзүүлсэн, мөн би та нарын үйлийг мэднэ.

36 Мөн та нар зүрх сэтгэлийнхээ бардамналд “алхдагийг би мэднэ; мөн ^бтансаг өмсгөл өмсөх, атаархах, мөн хэрүүл маргаан, мөн хорсол, мөн хавчлага, мөн бүх төрлийн алдсыг хийх хүртлээ зүрх сэтгэлийнхээ бардамналд өөрсдийгөө “өргөдөггүй цөөнөөс өөр хэн ч үгүй; мөн та нарын сүмүүд, тийм ээ, бүр нэг бүрчлэн, та нарын зүрх сэтгэлийн бардамналын улмаас бохирджээ.

37 Учир нь болгоогун, та нар ядуу мөн гачигдалтай, өвчтэй мөн шаналсныг хайрладгаасаа илүүгээр, та нар “мөнгөнд мөн өөрсдийн эд хөрөнгө, мөн өөрсдийн тансаг өмсгөл, мөн өөрсдийн сүмийн чимгүүддээ дуртай.

38 Ай өөрсдийгөө, ялзрах

түүний төлөө худалдах бохирдлууд та нар, хоёр нүүртнүүд та нар, багш нар та нар, яагаад та нар Бурханы ариун сүмийг бохирдуулсан бэ? Яагаад та нар Христийн нэрийг өөрсөд дээрээ авахаас “ичнэ вэ? Яагаад та нар үргэлжийн аз жаргалын үнэ цэнэ хэзээ ч үл мөхөх “зовлонгийнхоос агуу гэж үл бодно вэ—дэлхийн “магтаалын улмаас тэр үү?

39 Яагаад та нар амьгүй болох түүгээр өөрсдийгөө чимэглэх мөртлөө өлсгөлөн, мөн гачигдалтай, мөн нүцгэн, мөн өвчтэй, мөн шаналсан нь хажуугаар тань өнгөрөн одохыг зөвшөөрч, мөн тэднийг эс анзаарна вэ?

40 Тийм ээ, яагаад та нар эд хөрөнгө олохоор “нууц жигшүүрт хэргүүдээ сэдэж, мөн бэлэвсэрсэн нь Их Эзэний өмнө гашуудаж, мөн өнчин нь түүнчлэн Их Эзэний өмнө гашуудаж, мөн түүнчлэн тэдний эцгүүдийн мөн нөхрүүдийнх нь цус газраас Их Эзэнд хандан, та нарын толгой дээр өш хонзон авхын тулд гуйн залбирах болгоно вэ?

41 Болгоогтун, та нарын дээр өс хонзонгийн илд далайгаастай байна; мөн тэрбээр цаашид тэдний залбирлыг тэвчихгүйн учир, тэрбээр гэгээнтнүүдийн цусны “өшөөг

36а су Алхах,
Бурхантай хамт
алхах.
б Алма 5:53.
в Иаков 2:13.

37а 2 Ниф. 28:9–16.
38а Ром 1:16; 2 Тиа. 1:8;
1 Ниф. 8:25–28;
Алма 46:21.
б Мозая 3:25.

в 1 Ниф. 13:9.
40а су Нууц
хуйвалдаанууд.
41а 1 Ниф. 22:14.

та нараас авах тэр цаг удахгүй ирнэ.

БҮЛЭГ 9

Христэд үл итгэх тэднийг наманчлахыг Моронай уриалав— Илчлэлтүүдийг өгч мөн итгэлтэй тэдний дээр бэлэг хийгээд тэмдгүүдийг цутгадаг гайхамшигийн Бурханыг тэрбээр тунхаглав—Итгэлгүйн улмаас гайхамшигууд зогсдог—Итгэсэн тэднийг тэмдгүүд дагадаг—Хүмүүс ухаалаг байж, мөн зарлигуудыг дагахаар ухуулагдав. Ойролцоогоор мэ 401–421 он.

Мөн эдүгээ, би түүнчлэн Христэд итгэдэггүй тэдний талаар ярья.

2 Болгоогтун, зочлолын тэр өдөр л та нар итгэх юм уу—болгоогтун, Их Эзэн ирэхэд, тийм ээ, бүр газар дэлхий хуйлмал бичиг мэт “хуйлагдаж, мөн бичил хэсгүүд гал халуунд ^бхайлах тэр ^аагуу өдөр, тийм ээ, та Бурханы Хурганы өмнө зогсохоор авчрагдах тэр агуу өдөр—тэгэхэд та нар Бурхан гэж үгүй хэмээн хэлэх үү?

3 Тэгээд та нар цаашид Христийг үгүйсгэх үү, эсвээс Бурханы Хургыг болгоож чадах уу? Гэмээ ухамсарласнаар та нар түүнтэй цуг орших болно хэмээн та нар бодно

уу? Та нарын бодгаль та нар түүний хуулиудыг үргэлж зөрчдөг байсан тэрхүү гэрийнхээ ухамсартайгаар тарчилж байхад, та нар тэрхүү ариун Нэгэнтэй хамт оршихдоо аз жаргалтай байж чадна гэж та нар бодно уу?

4 Болгоогтун, би та нарт хэлнэ, та нар түүний өмнө бузар булайн ухамсартайгаар, ариун бөгөөд шударга Бурхантай хамт орших нь, та нар “тамд ^бяллагдсан бодгалиудтай оршсоноос илүү зовлонтой байх болно.

5 Учир нь болгоогтун, та нар Бурханы, мөн түүнчлэн Бурханы алдар суу, мөн Есүс Христийн ариун байдлын өмнө өөрсдийн “нүцгэн байдлыг үзэхээр авчрагдах үед, энэ нь та нарын дээр унтаршгүй галын дөл асаах болно.

6 Ай тэгвэл “үл итгэдэг та нар, та нар Их Эзэнд ^бхандагтун; та нар тэр агуу хийгээд эцсийн өдөр, “Хурганы цусаар цэвэрлэгдсэн учир толбогүй, ^сцэвэр ариун, хонгорхон, мөн цагаанаар олдох магадын учир, Есүсийн нэрээр Эцэгт хандан хүчтэйгээр залбиран гуйгтун.

7 Мөн түүнчлэн Бурханы илчлэлтүүдийг “үгүйсгэж, мөн тэдгээр нь зогссон, илчлэлтүүд, мөн бошиглолууд, мөн бэлгүүд, мөн эдгээх хүч, мөн

9 2а Морм. 5:23;
С ба Г 63:20–21.
су Дэлхий—
Дэлхийн Төгсгөл.
б Амос 9:13;
3 Ниф. 26:3.
в Малах. 4:5;

3 Ниф. 28:31.
4а су Там.
б су Ял.
5а 2 Ниф. 9:14.
6а су Итгэлгүй
байдал.
б Езек. 18:23, 32;

С ба Г 98:47.
в су Бурханы Хурга.
г су Цэвэр ариун,
Цэвэр ариун
байдал.
7а 3 Ниф. 29:6–7.

хэлээр ярих, мөн хэлийг ^бхөрвүүлэх нь үгүй болсон хэмээн хэлэх та нарт би ярина;

8 Болгоогтун би та нарт хэлнэ, эдгээр зүйлсийг үгүйсгэдэг тэр нь Христийн “сайн мэдээг мэддэггүй; тийм ээ, тэрээр судруудыг уншсан нь үгүй; хэрэв уншсан аваас, тэрээр тэдгээрийг ^бойлгосон нь үгүй.

9 Учир нь Бурхан өчигдөр, өнөөдөр, мөн үүрд “адил, мөн түүнд хувиралт мөн өөрчлөлтийн сүүдэр ч үгүйг бид уншдаг бус уу?

10 Мөн эдүгээ, хэрэв та нар хувирах мөн өөрчлөлтийн сүүдэртэй тийм бурханыг өөрсдөдөө төсөөлдөг аваас, тэгвэл та нар өөрсдөдөө гайхамшгийн Бурхан биш болох тийм бурханыг төсөөлжээ.

11 Гэвч болгоогтун, би та нарт гайхамшгийн Бурханыг, бүр Абрахамын Бурхан, мөн Исаакийн Бурхан, мөн Иаковын Бурханыг үзүүлэх болно; мөн энэ нь тэнгэр ба газрыг, мөн тэдгээрт байх бүх зүйлсийг бүтээсэн тэрхүү “Бурхан болой.

12 Болгоогтун, тэрбээр Адамыг бүтээсэн, мөн “Адамаар хүмүүний ^буналт ирсэн бөлгөө. Мөн хүмүүний уналтын улмаас Есүс Христ, бүр Эцэг

мөн Хүү ирсэн билээ; мөн Есүс Христийн улмаас хүмүүний ^бгэтэлгэл ирсэн юм.

13 Мөн Есүс Христээр ирсэн хүмүүний гэтэлгэлийн улмаас, тэд Их Эзэний өмнө буцаан хүргэгдэнэ; тийм ээ, бүхий л хүмүүн гэтэлгэгдэх нь үүгээр ирэх болно, учир нь нэгэн эцэсгүй “нойрноос гэтэлгэлийг улируулан тохиолгох тэр ^бамилуулалтыг Христийн үхэл улируулан тохиолгодог, мөн бүрээ дуугарахад бүх хүмүүн Бурханы хүчээр тэрхүү нойрноос сэргээгдэх болно; мөн бага мөн агуу аль аль нь болох тэд гарч ирж, мөн биеийн үхэл болох тэрхүү үхлийн мөнхийн “хүлээснээс гэтэлгэгдэн мөн алдуурагдсан учир, бүгдээрээ түүний тавцангийн өмнө зогсох болно.

14 Мөн тэгэхэд тэдний дээр Ариун Нэгэний “шүүлт ирэх болно; мөн тэгээд ^ббузар нэгэн нь бузраараа үлдэнэ; мөн зөв шударга тэр нь зөв шударгаараа байж, аз жаргалтай тэр нь аз жаргалтайгаараа байж; мөн аз жаргалгүй тэр нь аз жаргалгүй хэвээр байх тэр цаг ирнэ.

15 Мөн эдүгээ, Ай “гайхамшгийг бүтээж эс чадах нэгэн бурхныг өөрсдөдөө төсөөлсөн

7б 1 Кор. 12:7–10;
ИТ 1:7.

8а су Сайн Мэдээ.
б Мат. 22:29.

9а Евр. 13:8;
1 Ниф. 10:18–19;
Алма 7:20;
Моро. 8:18;
С ба Г 20:12.

11а Эхл. 1:1; Мозая 4:2;
С ба Г 76:20–24.
су Есүс Христ.

12а Мозая 3:26.
б су Адам Ева хоёрын
Уналт.
в су Гэтэлгэх,
Гэтэлгэгдэх,
Гэтэлгэл.

13а С ба Г 43:18.

б Хил. 14:15–18.

в С ба Г 138:16.

14а су Эцсийн шүүлт.

б Алма 7:21;
С ба Г 88:35.

15а Моро. 7:35–37;

С ба Г 35:8.

су Гайхамшиг.

та нар бүгд, би та нараас асууя, миний ярьсан эдгээр зүйлүүд бүгд тохиосон уу? Төгсгөл ирчихсэн гэж үү? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй; мөн Бурхан гайхамшигийн Бурхан байхаа болиогүй байна.

16 Болгоогтун, Бурханы үйлдсэн зүйлс бидний нүдэнд гайхамшигтай бус гэж үү? Тийм ээ, мөн Бурханы гайхамшигт “ажлуудыг хэн ухаарах билээ?

17 Түүний “үгээр тэнгэр болон дэлхий бий болгогдсоныг хэн гайхамшиг биш гэх билээ; мөн түүний үгийн хүчээр дэлхийн ⁶тоосноос хүмүүн ⁶бүтээгдсэн; мөн гайхамшигууд нь түүний үгийн хүчээр үйлдэгдсэн үү?

18 Мөн Есүс Христ олон хүчит “гайхамшигийг үйлдээгүй хэмээн хэн хэлэх билээ? Мөн төлөөлөгчдийн гараар олон хүчит гайхамшигууд үйлдэгдсэн юм.

19 Мөн хэрэв тэр үед “гайхамшигууд үйлдэгдсэн аваас, яагаад Бурхан гайхамшигийн Бурхан байхаа больсон атал өөрчлөгдөшгүй Нэгэн хэвээр байх билээ? Мөн болгоогтун, би та нарт хэлнэ, тэр өөрчлөгдөх нь үгүй; хэрэв тэгдэг аваас тэрбээр Бурхан байхаа болино; мөн тэрбээр Бурхан байхаа болих нь үгүй; мөн

тэр бол гайхамшигийн Бурхан болой.

20 Мөн хүмүүний үрсийн дунд тэрбээр “гайхамшигуудыг үйлдэхээ больдгийн шалтгаан нь тэд итгэлгүйдээ бууран доройтож, мөн зөв замаас холдон, мөн тэд ⁶найдвал зохих тэр Бурханыг эс мэддэгийн улмаас буюу.

21 Болгоогтун, би та нарт хэлнэ, Христэд эргэлзээгүйгээр итгэх хэн боловч, тэрбээр Эцэгээс Христийн нэрээр “юуг ч гуйсан тэр нь түүнд өгөгдөх болно; мөн энэ амлалт нь бүгдэд, бүр дэлхийн хязгааруудад ч адил буюу.

22 Учир нь болгоогтун, Есүс Христ, Бурханы Хүү, үлдэх учиртай өөрийн шавь нарт, тийм ээ, мөн түүнчлэн өөрийн бүх шавь нарт, цугларсан олонд сонсогдохоор: та нар бүх дэлхийгээр “явагтун, мөн хүмүүн бүрт сайн мэдээг номлогтун хэмээн хэлжээ.

23 Мөн итгэж мөн баптисм хүртсэн тэр нь аврагдах болно, гэвч итгэдэггүй тэр нь “яллагдах болно.

24 Мөн эдгээр “тэмдгүүд итгэдэг тэднийг дагана—миний нэрээр тэд ⁶чөтгөрүүдийг зайлуулна; тэд шинэ хэлээр ярих болно; тэд могойнуудыг барьж авах болно; мөн тэд

16a Дуул. 40:5;
С ба Г 76:114;
Моце 1:3–5.

17a Иаков 4:9.
б Эхл. 2:7; Мозая 2:25.
в су Бүтээх, Бүтээл.
18a Иохан 6:14.

19a С ба Г 63:7–10.
20a Шүүгч. 6:11–13;
Ифер 12:12–18;
Моро. 7:35–37.

б су Итгэл.
21a Мат. 21:22;
3 Ниф. 18:20.

22a Марк 16:15–16.
су Номлолын ажил.
23a су Ял.
24a Марк 16:17–18.
су Тэмдэг.
б Үйлс 16:16–18.

үхлийн аюулт юуг ч уусан тэр нь тэднийг гэмтээхгүй; тэд “гараа өвчөн дээр тавихад мөн тэд эдгэнэ;

25 Мөн эргэлзээгүйгээр миний нэрэнд итгэдэг хэнд боловч, түүнд, бүр дэлхийн хязгааруудад хүртэл би өөрийн бүх үгийг “нотлох болно.

26 Мөн эдүгээ, болгоогтун, Их Эзэний ажлын эсрэг хэн зогсож чадах билээ? Түүний хэлснийг “хэн үгүйсгэж чадах билээ? Их Эзэний бүхнийг чадагч хүчийн эсрэг хэн босох билээ? Их Эзэний ажлыг хэн үзэн ядах билээ? Христийн хүүхдүүдийг хэн үзэн ядах билээ? Болгоогтун, Их Эзэний ажлыг ^бүзэн ядагч та нар бүгдээр, учир нь та нар гайхширч мөн үрэгдэх болно.

27 Ай тэгвэл бүү үзэн яд, мөн бүү гайхшир, харин Их Эзэний үгсийг анхааран сонс, мөн өөрт хэрэгцээтэй ямар ч зүйлийн төлөө Эцэгээс, Есүсийн нэрээр гуй. Бүү эргэлз, харин итгэлтэй бай, мөн эрт цагийнхны адилаар эхэл, мөн бүх “зүрх сэтгэлээрээ Их Эзэнд ^бирэгтүн, мөн түүний өмнө айж мөн сүрдсэнээр авралаа ^ггүйцээгтүн.

28 Сорилтынхоо өдрүүдэд “ухаалаг бай; бүх цэвэр бусыг өөрсдөөсөө зайлуул; ^бшунал

хүслээрээ үүнийг үрж дуусгаж болохын тулд бүү гуй, харин та нар ямар ч уруу таталтанд байр тавилгүй, харин та нар үнэн хийгээд “амьд Бурханд үйлчилнэ гэсэн гуйвшгүй шийдмэг байдалтайгаар гуй.

29 “Зохисгүйгээр баптисм хийлгэхгүй байхаа мэд; ^бзохисгүйгээр Христийн ариун ёслолоос хүртэхгүй байхаа мэд; харин бүх зүйлийг “зохистойгоор хийхээ, мөн амьд Бурханы Хүү, Есүс Христийн нэрээр хийхээ мэд; мөн хэрэв та нар үүнийг хийж, мөн эцсээ хүртэл тэвчих аваас, та нар явч зайлуулагдах учиргүй.

30 Болгоогтун, би нас барагсдаас “ярьж буй мэтээр би та нарт ярьж байна; учир нь та нар миний үгсийг авна гэдгийг би мэднэ.

31 Миний төгс бусын улмаас намайг, бас түүний “төгс бусын улмаас эцгийг минь ч, бас түүний өмнө бичсэн тэднийг ч бүү буруушаа; харин та нар бидний байснаас илүү ухаалаг байхад сурч болохын тулд, бидний төгс бусыг та нарт илчилсэнд нь Бурханд талархлаа мэдүүл.

32 Мөн эдүгээ, болгоогтун, энэ цэдгийг, бидний ярианы маягийн дагуу, биднээр доош

24в су Өвчтөнийг эдгээх.

25а су Илчлэлт; Гэрчлэл.

26а 3 Ниф. 29:4–7.
б Сур. үгс 13:13.

27а Иош. 22:5;
С ба Г 64:22, 34.
су Зүрх сэтгэл.

б Моро. 10:30–32.

в Филип. 2:12.

28а Иаков 6:12.

б су Тачаадах.

в Алма 5:13.

29а су Баптисм,
Баптисм хүртээх—

Баптисмд тэнцэх.

б 1 Кор. 11:27–30;

3 Ниф. 18:28–32.

в су Зөв зохистой,

Зөв зохистой
байдал.

30а Морм. 8:26;

Моро. 10:27.

31а Морм. 8:17;

Ифер 12:22–28, 35.

дамжигдан мөн өөрчлөгдсөн, “шинэчлэгдсэн египет хэмээн бидний дунд нэрлэгддэг үсгүүдээр бид өөрсдийн мэдлэгийн дагуу бичсэн болой.

33 Мөн хэрэв бидний ялтсууд хангалттай том байсан аваас бид еврей хэл дээр бичих байсан; гэвч еврей хэл түүнчлэн биднээр шинэчлэгдсэн бөлгөө; мөн хэрэв бид еврей хэл дээр бичиж чадсан бол, болгоогтун, бидний цэдэгт та нар төгс бус юуг ч эс олох байсан.

34 Гэвч Их Эзэн бидний бичсэн зүйлсийг, мөн түүнчлэн өөр ямар ч хүмүүс бидний хэлийг эс мэднэ гэдгийг мэднэ; мөн бидний хэлийг өөр ямар ч хүмүүс эс мэдэхийн учир, тиймийн учир үүний хөрвүүлгийн төлөө тэрбээр нэгэн “хэрэгслийг бэлтгэсэн болой.

35 Мөн “итгэлгүйдээ бууран доройтсон ах дүүсийнхээ цусыг өмсгөлөөсөө арилгахын тулд эдгээр зүйлүүд бичигдсэн бөлгөө.

36 Мөн болгоогтун, ахан дүүсийнхээ талаар бидний “хүссэн эдгээр зүйлс, тийм ээ, учир нь, Христийн мэдлэг дэх тэдний сэргээлт уг нутагт оршин сууж асан бүх гэгээнтнүүдийн залбирлуудын дагуу буюу.

37 Мөн тэдний итгэлийн дагуу залбирлууд нь хариулагдаж болохыг Их Эзэн Есүс Христ зөвшөөрөх болтугай; мөн Бурхан Эцэг Израилын угсаатай хийсэн гэрээгээ санах болтугай; мөн тэрбээр тэднийг Есүс Христийн нэрэнд итгэх итгэлээр нь дамжуулан үүрд адислах болтугай. Амен.

ИФЕРИЙН НОМ

Мозая хааны өдрүүдэд, Лимхайн хүмүүсээр олдсон хорин дөрвөн Ялтсаас авагдсан жаредчуудын цэдэг оршвой.

БҮЛЭГ 1

Иферийн бичээсийг Моронай хураангуйлав—Иферийн удмын бичиг таниулагдав—Жаредчуудын хэл Бабелын Цамхагт үл бусниулагджээ—Их Эзэн тэд-

нийг сонгомол нутаг тийш хөтөлж мөн тэднийг агуу үндэстэн болгохоор амлав.

МӨН одоо би, “Моронай, Хойд зүгийн энэ нутгийн гадаргуу дээр Их Эзэний

32а 1 Ниф. 1:2;
Мозая 1:4.
34а Мозая 8:13–18;
Ифер 3:23, 28;

С ба Г 17:1.
35а 2 Ниф. 26:15.
36а Морм. 8:24–26;
С ба Г 10:46–49.

[ИФЕР]
1 1а су Моронай,
Мормоны хүү.

ᵇмутраар устгагдсан эртний оршин суугчдын шастирыг өгөхөө үргэлжлүүлье.

2 Мөн би өөрийн шастирыг Лимхайн хүмүүсээр олдсон, Иферийн Ном хэмээн нэрлэгдэх “хорин дөрвөн ялтсаас авах болно.

3 Мөн дэлхийн, мөн түүнчлэн Адамын үүслийн талаар өгүүлэх мөнхүү тэр цагаас агуу “цамхгийг хүртэлх шастир, мөн тэр цагийг хүртэл хүмүүний үрсийн дунд тохиосон бүх зүйлүүд бүхий энэхүү цэдгийн эхний хэсэг нь иудейчүүдийн дунд байсаар ирсэн хэмээн би таамаглах буюу —

4 Тиймийн тул “Адамын өдрүүдээс тэр цагийг хүртэл тохиосон тэдгээр зүйлийг би үл бичнэ; харин тэдгээр нь ялтсууд дээр буй; мөн тэдгээрийг олсон хэн боловч, чухамхүү тэр нь бүрэн шастирыг авч болох хүчтэй болно.

5 Гэвч болгоогтун, би бүхэл шастирыг эс өгнө, харин цамхгаас тэд устгагдах хүртэл шастирын хэсгийг би өгье.

6 Мөн ийм маягаар би шастирыг өгье. Энэ цэдгийг бичсэн тэр нь “Ифер байсан ажгуу, мөн тэрээр Корианторын удам байв.

7 Кориантор нь Мороны хүү байв.

8 Мөн Морон нь Ифемийн хүү байв.

9 Мөн Ифем нь Ахагийн хүү байв.

10 Мөн Аха нь Сетийн хүү байв.

11 Мөн Сет нь Шиблоны хүү байв.

12 Мөн Шиблон нь Комын хүү байв.

13 Мөн Ком нь Кориантумын хүү байв.

14 Мөн Кориантум нь Амнигадгагийн хүү байв.

15 Мөн Амнигадда нь Аароны хүү байв.

16 Мөн Аарон нь Хирфомын хүү асан Хетийн удам байв.

17 Мөн Хирфом нь Либийн хүү байв.

18 Мөн Либ нь Кишийн хүү байв.

19 Мөн Киш нь Коромын хүү байв.

20 Мөн Кором нь Ливайн хүү байв.

21 Мөн Ливай нь Кимийн хүү байв.

22 Мөн Ким нь Мориантоны хүү байв.

23 Мөн Мориантон нь Риплакишийн удам байв.

24 Мөн Риплакиш нь Шезийн хүү байв.

25 Мөн Шез нь Хетийн хүү байв.

26 Мөн Хет нь Комын хүү байв.

27 Мөн Ком нь Кориантумын хүү байв.

28 Мөн Кориантум нь Имерийн хүү байв.

29 Мөн Имер нь Омерын хүү байв.

30 Мөн Омер нь Шулегийн хүү байв.

1ᵇ Морм. 5:23;
С ба Г 87:6–7.
2а Алма 37:21;
Ифер 15:33.

3а Омнаи 1:22;
Мозая 28:17;
Хил. 6:28.
4а ө.х. Эхлэлийн бүлэг

1-10-тай адил үед
хамаарна.
6а Ифер 12:2; 15:34.

31 Мөн Шуле нь Кибийн хүү байв.

32 Мөн Киб нь Жаредын хүү асан, Ораихагийн хүү байв;

33 Хүмүүсийн хэлийг “будлиулсан, мөн тэд дэлхийн бүх “гадаргуу дээр тараагдах болно хэмээн Их Эзэн хилэгнэлдээ тангарагласан тэр цагт, өөрийн ах болон тэдний гэр бүлтэй, бусад зарим болон тэдний гэр бүлүүдийн хамтаар тэрхүү “Жаред сайхь агуу цамхгаас одсон ажээ; мөн Их Эзэний үгийн дагуу хүмүүс тараагдав.

34 Мөн Жаредын “ах том биетэй мөн хүчирхэг эр, мөн Их Эзэний өндөр их ээл хишгийг хүртсэн эр болохын учир, түүний дүү, Жаред, түүнд хандаж хэлсэн нь: Тэрээр биднийг бусниулснаас бид өөрсдийн үгийг үл ойлголцоход хүрэхгүйн тулд Их Эзэнээс залбиран гуй.

35 Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах Их Эзэнээс залбиран гуйсан бөгөөд, мөн Их Эзэн Жаредыг өрөвдөн хайрлав; тиймийн тул тэр Жаредын хэлийг бусниулсангүй; мөн Жаред мөн түүний ах бусниулагдсангүй.

36 Тэгээд Жаред ахдаа хэлсэн нь: Тэрээр уур хилэнгээ бидний найзууд болох тэднээс холдуулснаар тэдний хэлийг үл бусниулахын тулд Их Эзэнээс дахин залбиран гуйгтун.

37 Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах Их Эзэнээс залбиран гуйв, мөн түүнчлэн Их Эзэн тэдний найзуудыг мөн тэдний гэр бүлүүдийг өрөвдөн хайрласнаас, тэд үл бусниулагдав.

38 Мөнхүү улиран тохиох дор Жаред ахтайгаа дахин ярьж, хэлрүүн: Явж мөн тэрээр биднийг энэ нутгаас хөөн гаргах эсэхийг Их Эзэнээс лавлагтун, мөн хэрэв тэрээр биднийг энэ нутгаас хөөн гаргах аваас, бид хааш одохыг түүнээс залбиран асуугтун. Мөн бүх дэлхийд бүгдээс “дээгүүр сонгомол болох тэрхүү нутагт Их Эзэн биднийг хүргэх эсэхийг хэн мэдэх билээ? Мөн хэрэв тийм байх аваас, бид түүнийг өөрсдийн өв болгон хүлээн авч болохын тулд, Их Эзэнд итгэлтэй байцгаая.

39 Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах Их Эзэнд хандан Жаредын амаар хэлэгдсэн тэдгээрийн дагуу залбиран асуусан аж.

40 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Жаредын ахыг сонсон, мөн түүнийг өрөвдөн хайрлаж, мөн түүнд хэлсэн нь:

41 Явж мөн өөрийн бүх л төрлийн эр ч бай эм ч бай мал сүргээ; мөн бас бүх л төрлийн дэлхийн үрээс; мөн “гэр бүлийнхнээ; мөн бас өөрийн дүү Жаред болон түүний гэр бүлийг; мөн бас “найзуудаа мөн тэдний гэр бүлүүдийг

33a Эхл. 11:6–9.
б Мозая 28:17.
в су Жаред.

34a су Жаредын ах.
38a су Амлалтын нутаг.
41a Ифер 6:20.

б Ифер 6:16.

мөн Жаредын найзууд болон тэдний гэр бүлүүдийг цуглуулагтун.

42 Мөн үүнийг хийж дууссаныхаа дараа тэдний тэргүүнд хойд зүгт орших хөндий тийш уруудан “явагтун. Мөн тэнд би чамтай уулзах болно, мөн би чиний^б өмнө дэлхийн бүх газруудаас дээгүүрт “сонгомол тэр нутаг тийш явах болно.

43 Мөн тэнд би чамайг болон чиний үр удмыг адислах болно, мөн чиний үр удмаас, мөн чиний дүүгийн үр удмаас, мөн чамтай цуг явах тэднээс, агуу үндэстнийг би өөртөө өсгөнө. Мөн дэлхийн бүх л гадаргуу дээр чиний үр удмаас би өөртөө өсгөн авах тэр үндэстнээс илүү агуу нь үгүй болой. Мөн чи надад хандан ийм удаан хугацаагаар залбиран гуйсны учир би чамд тийн үйлдэх буюу.

БҮЛЭГ 2

Жаредчууд амлагдсан газар тийш аялалдаа бэлтгэв—Энэ нь хүмүүс тэнд Христэд үйлчлэх эс бөгөөс арчигдах ёстой сонгомол нутаг болой—Их Эзэн Жаредын ахтай гурван цагийн туршид ярив—Жаредчууд далайн хөлгүүдийг босгов—Хөлгүүд нь хэрхэн гэрэлтүүлэгдэхийг бодож олохыг Их Эзэн Жаредын ахаас хүсэв.

Мөнхүү улиран тохиох дор

Жаред мөн түүний ах, мөн тэдний гэр бүлүүд, мөн түүнчлэн Жаредын найзууд, мөн түүний ах мөн тэдний гэр бүлүүд, бүх л төрлийн эр ч бай эм ч бай, цуглуулсан мал сүрэгтэйгээ хойд зүгт орших хөндий тийш (мөн хөндийн нэр нь “Нимрод хэмээн хүчит анчны нэрээр нэрлэгдсэн байв) уруудан явав.

2 Мөн түүнчлэн тэд тор тавин мөн агаарын жигүүртнийг барив, мөн усны загасыг өөрсөдтэйгөө авч явах тэр савыг тэд түүнчлэн бэлтгэв.

3 Мөн тэд түүнчлэн балт зөгий хэмээгдэн хөрвүүлэгдэх дезеретийг өөрсөдтэйгээ авч явав, мөн тэд тийн дэлхийн гадаргуу дээр байсан бүл зөгийнүүдийг, мөн бүхий зүйлсээс, бүх л төрлийн үрийг өөрсөдтэйгээ авч явав.

4 Мөнхүү улиран тохиох дор тэд уруудан Нимродын хөндийд ирэхэд Их Эзэн бууж ирээд мөн Жаредын ахтай ярив; мөн тэрээр “үүлэн дунд байж, мөн Жаредын ах түүнийг үл харсан аж.

5 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн аглаг буйд тийш, тийм ээ, хэзээ ч хүн хүрээгүй тэр хэсэг тийш явахыг тэдэнд зарлиглав. Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн тэдний өмнө яван, мөн тэр “үүлэн дунд зогсохдоо тэдэнтэй ярьж, мөн тэдний хааш аялахыг зааварлав.

42а 1 Ниф. 2:1–2;
Абр. 2:3.
б С ба Г 84:88.

в 1 Ниф. 13:30.
21а Эхл. 10:8.
4а Тоол. 11:25;

С ба Г 34:7–9;
ИС—Т 1:68.
5а Ег. 13:21–22.

6 Мөнхүү улиран тохиох дор тэд аглаг буйдаар аялж, мөн хөлгүүдийг босгож, Их Эзэний мутраар үргэлжид удирдуулан, түүгээр тэд их усыг гатлав.

7 Мөн Их Эзэн тэдэнд тэнгисийн цаадах аглаг буйдад зогсохыг нь үл зөвшөөрөн, харин тэрээр тэднийг Их Эзэн Бурханы зөв шударга хүмүүст хадгалсан бүх бусад нутгуудаас сонгомол болох, бүр амлалтын “нутагт хүртэл явахыг хүсэв.

8 Мөн тэр цагаас эхлэн мөн үүрд энэхүү амлалтын нутгийг эзэмших хэн боловч, өөрт нь, үнэн бөгөөд цорын ганц Бурханд “үйлчлэх учиртай, эс бөгөөс түүний хилэн тэр чигээрээ тэдний дээр ирэхэд тэд ⁶арчигдах болно хэмээн тэрээр Жаредын ахад уур хилэндээ тангарагласан байв.

9 Мөн эдүгээ, энэ нутгийн талаар Бурханы тогтоолыг, энэ нь амлалтын нутаг гэдгийг бид болгоож чадна; мөн үүнийг эзэмших ямар ч үндэстэн Бурханд үйлчлэх болно, эс бөгөөс түүний хилэн тэр чигээрээ тэдний дээр ирэхэд тэд арчигдах болно. Мөн тэд алдастаа бүрнээ боловсорсон үед түүний хилэн тэр чигээрээ тэдний дээр ирнэ.

10 Учир нь болгоогтун, энэ бол бусад бүх нутгуудаас сонгомол тэрхүү нутаг болой;

иймийн тул үүнийг эзэмших тэр нь Бурханд үйлчлэх буюу, эс бөгөөс арчигдах болно; учир нь энэ бол Бурханы үүрдийн тогтоол юм. Мөн уг нутгийн үрсийн дунд “алдас бүрэн дүүрэн болтол, тэд ⁶арчигдах нь үгүй.

11 Мөн энэ нь та нарт ирнэ, Ай “харийнхан та нар, та нар Бурханы тогтоолуудыг мэдэж болохын тулд — та нар наманчилж, мөн бүрэн дүүрэн нь ирэх хүртэл алдсаа үргэлжлүүлэхгүй байж болохын учир, уг нутгийг өвлөгчид өмнө нь үйлдсэний адилаар Бурханы уур хилэнгийн бүрэн дүүрнийг та нар өөрсөд дээрээ авчрахгүй байж болохын тулд мөн энэ нь та нарт ирнэ.

12 Болгоогтун, энэ бол сонгомол нутаг, мөн үүнийг эзэмшигч ямарваа үндэстэн, хэрэв тэд уг нутгийн Бурхан, бидний бичсэн зүйлсээр үзүүлэгдсэн Есүс Христэд л зөвхөн “үйлчлэх аваас, дарангуйллаас, мөн боолчлолоос, мөн тэнгэрийн доорх бусад бүх үндэстнээс ⁶ангид байх болно.

13 Мөн эдүгээ би цэдгээ үргэлжжүүлье; учир нь болгоогтун, улиран тохиох дор Их Эзэн Жаред мөн түүний ахан дүүсийг газрыг хуваагч тэрхүү агуу далайд урагш авчрав. Мөн тэд далайн дэргэд ирээд майхнаа тэд босгов;

7a 1 Ниф. 4:14.
су Амлалтын нутаг.
8a Ифер 13:2.
б Жером 1:3, 10;

Алма 37:28;
Ифер 9:20.
10a 2 Ниф. 28:16.
б 1 Ниф. 17:37–38.

11a 2 Ниф. 28:32.
12a Иса. 60:12.
б су Эрх чөлөө.

мөн тэд уг газрын нэрийг Морианкумер гэв; мөн тэд майхнуудад амьдарч байв, далайн эрэг дээр дөрвөн жилийн туршид майхнуудад амьдарсан ажгуу.

14 Мөнхүү улиран тохиох дор дөрвөн жилийн шувтарганд Их Эзэн Жаредын ахад дахин ирж, мөн үүлэн дунд зогсоод түүнтэй ярив. Мөн гурван цагийн турш Их Эзэн Жаредын ахтай ярьж, тэрээр Их Эзэний нэрийг “дуудахаа эс санасных нь учир түүнийг ^бэмлэв.

15 Мөн Жаредын ах өөрийн хийсэн хилэнцэт үйлээ наманчлав, мөн өөртэйгөө хамт байсан ахан дүүсийнхээ төлөө Их Эзэний нэрийг дуудав. Мөн Их Эзэн түүнд хэлсэн нь: Чамайг болон ахан дүүсийг чинь нүглээс нь өршөөе би; харин та нар цаашид нүгэл үйлдэх ёсгүй, учир нь миний “Сүнс хүмүүний төлөө үргэлж ^бзүтгэх нь үгүй гэдгийг та нар санах болно; иймийн тул, хэрэв та нар бүрэн боловсрох хүртлээ нүгэл үйлдэх аваас Их Эзэний дэргэдээс та нар тусгаарлагдах болно. Мөн эдгээр нь би та нарт өвлүүлэн өгөх тэр нутгийн талаарх миний бодол юм; учир нь энэ нь бусад бүх нугтуудаас ^ссонгомол нутаг байх болно.

16 Мөн Их Эзэн хэлрүүн: Явж ажилла, мөн эдүгээгээс өмнө та нар босгож байсан

хөлгүүдийнхээ адил хөлгийг босгогтун. Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах, мөн түүнчлэн түүний ахан дүүс ажиллахаар явж, мөн тэд Их Эзэний “зааврын дагуу босгож байсныхаа адилаар хөлгүүдийг босгов. Мөн тэдгээр нь жижиг, мөн бүр тэдгээр нь усан дээр жигүүртэн хөнгөхөн байдгийн адилаар усан дээр тийм хөнгөн байв.

17 Мөн тэдгээр нь туйлын “нягт байхаар, бүр таваг лугаа адил усыг агуулахуйцаар баригджээ; мөн ёроол нь таваг лугаа адил нягт байв; мөн талууд нь таваг мэт нягт байв; мөн төгсгөлүүд нь дээш өргөгдсөн байв; мөн дээд тал нь таваг мэт нягт байв; мөн урт нь модны уртын адил байв; мөн үүд нь, хаалттай байхдаа, таваг мэт нягт байв.

18 Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах Их Эзэнд хандан залбирч, хэлсэн нь: Ай Их Эзэн, таны надад зарлигласан ажлыг би гүйцэлдүүлэв, мөн би таны заасны дагуу хөлгүүдийг бүтээлээ.

19 Мөн болгоогтун, Ай Их Эзэн, гэдэн дотор гэрэл үгүй болой; бид хааш залах вэ? Мөн бид дотор нь буй агаараас өөр амьсгалах зүйл үгүйн учир, түүнчлэн бид үрэгдэх буоу; тиймийн тул бид үрэгдэх болно.

20 Мөн Их Эзэн Жаредын ахад хандан өгүүлсэн нь: Болгоогтун, та нар оройд нь, мөн

14а су Залбирал.
б су Зэмлэх, Ээмлэл.
15а Ифер 15:19.

б Эхл. 6:3;
2 Ниф. 26:11;
Морм. 5:16.

в Ифер 9:20.
16а 1 Ниф. 17:50–51.
17а Ифер 6:7.

бас ёроолд нь нүхэлсүгэй; мөн агаар дутагдах үедээ нүхээ нээж мөн агаар оруулах болно. Мөн хэрэв та нар дээр ус орж ирэх аваас, та нар үерт үрэгдэхгүй байж болохын тулд болгоогтун, та нар уг нүхийг бөглөх болно.

21 Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах Их Эзэн зарлигласны дагуу хийсэн бөлгөө.

22 Мөн тэрээр Их Эзэнд хандан дахин залбирч, хэлрүүн: Ай Их Эзэн, болгоогтун таны надад зарлиг болсноор би хийв; мөн би өөрийн хүмүүст хөлгүүдийг бэлтгэв, мөн болгоогтун тэдэн дотор гэрэл үгүй байна. Болгоогтун, Ай Их Эзэн, бид энэ их усыг харанхуйд гатлахыг та зөвшөөрнө гэж үү?

23 Мөн Их Эзэн Жаредын ахад хандан хэлсэн нь: Та нар хөлгүүд дотроо гэрэлтэй байхын тулд намайг хэрхэхийг та нар хүснэ вэ? Учир нь болгоогтун, та нар хөлөгтөө цонхтой байж үл болно, учир нь тэдгээр нь хэдэн хэсэг бутрах болно; бас та нар өөрсөдтэйгөө гал авч явж үл болно, учир нь та нар галын гэрлээр явахгүй.

24 Учир нь болгоогтун, та нар далайн дундах халимтай адил байх болно; учир нь уулс мэт давалгаанууд та нар дээр буух болно. Гэсэн хэдий ч, би та нарыг далайн гүнээс дахин гаргаж ирэх болно; учир нь “салхи амнаас минь гарч, мөн

бас ⁶бороо болоод үерийг ч би илгээх болой.

25 Мөн болгоогтун, би та нарыг эдгээр зүйлсийн эсрэг бэлтгэх болно; учир нь би та нарыг далайн давалгаа, мөн урагш түрэх салхи, мөн ирэх үерийн эсрэг эс бэлтгэх аваас та нар энэхүү агуу гүнийг гаталж эс чадна. Тиймийн тул та нар далайн гүнд хучигдахын цагт та нар гэрэлтэй байхын тулд намайг та нар юу бэлтгээсэй хэмээн хүсч байна вэ?

БҮЛЭГ 3

Арванзургаан чулуунд хүрэх үед нь Жаредын ах Их Эзэний хурууг харав—Христ өөрийн сүнсний биеийг Жаредын ахад үзүүлэв—Төгс мэдлэг бүхий тэд гивлүүрийн доторхыг харахгүйгээр хадгалагдах аргагүй юм—Жаредчуудын цэдгийг гэрэлд авчрахад хөрвүүлэгчид хангагдав.

Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах (эдүгээ бэлтгэсэн хөлгийн тоо нь найм байв), үлэмж өндөр болохынх нь учир Шелем уул хэмээн тэдний нэрлэсэн уул өөд очиж, мөн хаднаас арван зургаан жижиг чулууг хайлуулан гаргаж авав; мөн тэдгээр нь цагаан бөгөөд тунгалаг, бүр нэвт харагдах шил лугаа адил байв; мөн уулын орой дээр тэрээр тэдгээрийг гартаа барин, мөн Их Эзэнд хандан залбирч хэлрүүн:

2 Ай Их Эзэн, та биднийг ус үерт хүрээлэгдэх ёстой хэмээн хэлсэн. Эдүгээ болгоогтун, Ай Их Эзэн, мөн таны өмнөх сул доройгоос нь болоод үйлчлэгчдээ бүү хилэгнээч; учир нь та бол ариун мөн тэнгэрт оршдог, мөн таны өмнө зохисгүйгээ бид мэднэ; “уналтын улмаас бидний ⁶төрөлхийн чанар үргэлжид хилэнцэт байхаар болсон юм; гэсэн хэдий ч, Ай Их Эзэн, танаас бид хүслийнхээ дагуу хүлээн авч болохын тулд бид таныг дуудах учиртай хэмээх зарлигийг та бидэнд өгсөн буюу.

3 Болгоогтун, Ай Их Эзэн, бидний алдсын улмаас та биднийг гэгсгээсэн, мөн биднийг нүүлгэсэн, мөн энэ олон жилийн туршид бид аглаг буйдад л байлаа; гэсэн хэдий ч, та бидэнд “нигүүлсэнгүй хандаж байсан. Ай Их Эзэн, намайг өрөвдөн хараач, мөн өөрийн энэ хүмүүсээс та уур хилэнгээ холдуулаач, мөн энэ догшин гүнийг тэд харанхуйд гатлахыг бүү зөвшөөрөөч; харин хаднаас миний хайлуулан гаргасан эдгээр зүйлсийг болгооно уу.

4 Мөн, Ай Их Эзэн, та бүх “хүчийг эзэмшдэг, мөн хүмүүний тусын тулд та ямарвааг хийж чадна гэдгийг би мэднэ; тиймийн тул эдгээр чулуунд хуруугаараа хүрээч, Ай Их Эзэн, тэдгээр нь

харанхуйд гэрэлтэж болохын тулд; мөн далайг гатлахдаа бид гэрэлтэй байж болохын тулд тэдгээрийг бэлтгээч, тэдгээр нь бидний бэлтгэсэн хөлгүүд дотор бидэнд гэрэл өгөх болно.

5 Болгоогтун, Ай Их Эзэн, та үүнийг хийж чадна шүү дээ. Та, хүмүүсийн ойлголтонд өчүүхэн мэт “харагддаг агуу хүчийг үзүүлж чадахыг бид мэднэ.

6 Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах эдгээр үгсийг хэлэхэд, болгоогтун, “Их Эзэн мутраа сунган мөн чулуунуудад нэг нэгээр нь хуруугаараа хүрэв. Мөн Жаредын ахын нүднээс ⁶гивлүүр сөхөгдөхөд, мөн Их Эзэний хурууг тэр харлаа; мөн энэ нь хүмүүний хуруутай адил, мах цустай мэт байв; мөн Жаредын ах Их Эзэний өмнө унав, учир нь тэрээр айдаст хүлэгдсэн ажгуу.

7 Мөн Их Эзэн Жаредын ах газарт унасныг харж; мөн Их Эзэн түүнд хандан хэлэв: Бос, чи юунд унав?

8 Мөн тэрээр Их Эзэнд хандан өчиж: Их Эзэний хурууг би харлаа, мөн тэр намайг цохих вий хэмээн айв би; Их Эзэн мах цустайг би эс мэдсэний учир буюу.

9 Мөн Их Эзэн түүнд хандан хэлсэн нь: Итгэлийн чинь улмаас би өөртөө “мах цусыг авах болно гэдгийг чи

3 2а су Адам Ева хоёрын Уналт.
6 Мозая 3:19.
3а Ифер 1:34–43.

4а су Хүч.
5а Иса. 55:8–9;
1 Ниф. 16:29.
6а су Есүс Христ.

6 Ифер 12:19, 21.
9а су Маханбодь; Есүс Христ; Мөнх бус, Мөнх бус байдал.

харлаа; мөн чиний нэгэн адил ийм үлэмж итгэлтэйгээр хүмүүн миний өмнө хэзээ ч ирж байсангүй; тийм бус аваас чи миний хурууг харж чадахгүй байсан. Чи үүнээс өөрийг харав уу?

10 Мөн тэрээр хариулсан нь: Үгүй; Их Эзэн, өөрийгөө надад үзүүлээч.

11 Мөн Их Эзэн түүнд хандан хэлрүүн: Миний ярих үгсэд чи итгэх үү?

12 Мөн тэрээр хариулсан нь: Тийм ээ, Их Эзэн, та үнэнийг ярьж буйг, учир нь та үнэний Бурхан болохыг, мөн “худал хэлж эс чадахыг би мэднэ.

13 Мөн тэрээр эдгээр үгсийг хэлэхэд, болгоогтун, Их Эзэн өөрийгөө түүнд “үзүүлэн, мөн хэлсэн нь: Чи эдгээр зүйлсийг ^бмэдэхийн учир чи уналтаас гэтэлгэгдсэн болой; тиймийн тул чи миний дэргэд буцаан хүргэгдлээ; тиймийн тул би чамд өөрийгөө “үзүүлж буй.

14 Болгоогтун, өөрийн хүмүүсийг “гэтэлгэхээр дэлхийн үүслээс бэлтгэгдсэн нь би болой. Болгоогтун, бибээр Есүс Христ. Бибээр ^бЭцэг мөн Хүү. Надаар бүх хүмүүн төрөлхтөн “амьдралыг, бүр миний нэрэнд итгэх тэд мөнхийн түүнийг хүртэх болно; мөн тэд миний охид, мөн миний “хөвгүүд болох болно.

15 Мөн чиний нэгэн адилаар надад хүмүүн “итгэж байсан нь үгүйн учир, өөрийн бүтээсэн хүмүүндээ, би хэзээ ч өөрийгөө үзүүлж байсан нь үгүй. Миний өөрийн ^бтөрхөөр чи бүтээгдсэн болохоо харж байна уу? Тийм ээ, бүр бүх хүмүүс эхлэлд миний өөрийн төрхөөр бүтээгдсэн билээ.

16 Болгоогтун, чиний болгоож буй энэ бие болбоос миний “сүнсний бие; мөн хүмүүнийг би өөрийн сүнсний биеийн адилаар бүтээсэн юм; мөн би сүнсэндээ чиний өмнө үзэгдэж буй ч би өөрийн хүмүүст маханбодиороо үзэгдэх болно.

17 Мөн эдүгээ, би, Моронай, эдгээр бичигдсэн зүйлүүдийн бүхэл шастирыг үйлдэж чадахгүйгээ би хэлсэн учир, тиймийн тул, бүр нифайчуудад өөрийгөө үзүүлснийхээ адил биеийн төрхөөр мөн маягаар, Есүс өөрийгөө энэ хүмүүнд сүнсээрээ “үзүүлсэн хэмээн хэлэх нь надад хангалттай юм.

18 Мөн тэрээр нифайчуудад тохинуулсныхаа адилаар түүнд тохинуулсан билээ; мөн энэ бүхэн, Их Эзэн түүнд үзүүлсэн олон агуу үйлсийн улмаас, энэ хүмүүн тэрбээр Бурхан болохыг мэдэж болохын тулд хийгдсэн буюу.

19 Мөн энэ хүмүүний мэдлэ-

12a Евр. 6:18.

13a С ба Г 67:10–11.

б Инос 1:6–8.

в су Есүс Христ—Христийн мөнх бус байдлын өмнөх амьдрал.

14a су Гэтэлгэх,

Гэтэлгэгдэх,

Гэтэлгэл; Гэтэлгэгч.

б Мозая 15:1–4.

в Мозая 16:9.

г су Бурханы хөвгүүд охид.

15a су Итгэлтэй байх, Итгэл.

б Эхл. 1:26–27;

Мозая 7:27;

С ба Г 20:17–18.

16a су Сүнс.

17a 3 Ниф. 11:8–10.

гийн улмаас тэрээр “гивлүүрийн доторхыг нэвт харах гүйгээр хадгалагдах аргагүй юм; мөн тэрээр Есүсийн хурууг харсан байв, түүнийг тэрээр хараад, энэ нь Их Эзний хуруу болохыг тэрээр мэдсэн учир, тэр айдастайгаар унасан ажгуу; мөн тэрээр ямар ч эргэлзээгүйгээр мэдэж байсан учир, тэрээр цаашид итгэхгүй байх аргагүй болжээ.

20 Иймийн тул, Бурханы энэ төгс мэдлэгийг агуулсны учир, тэрээр гивлүүрийн дотор “хадгалагдах аргагүй юм; тиймийн тул тэрээр Есүсийг харсан; мөн тэрбээр түүнд тохинуулсан буюу.

21 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Жаредын ахад хандан хэлрүүн: Болгоогтун, чи өөрийн үзсэн мөн сонссон эдгээр зүйлсийг, би өөрийн нэрийг маханбодиороо алдаршуулах тэр “цаг ирэх хүртэл, дэлхийнхэнд мэдэгдэхийг үл зөвшөөрөгтүн; иймийн тул, чи өөрийн үзсэн мөн сонссон зүйлсээ нандигнан хадгалах болно, мөн ямар ч хүмүүнд бүү үзүүлсүгэй.

22 Мөн болгоогтун, чи надад ирэхдээ, тэдгээрийг чи бичиж, мөн хэн ч хөрвүүлж эс чадахын тулд; тэдгээр нь уншигдаж чадахааргүй тийм хэл дээр чи тэдгээрийг бичихийн учир чи тэдгээрийг лацдах болно.

23 Мөн болгоогтун, энэ “хоёр чулууг би чамд өгье, мөн чи бичих тэр зүйлүүдтэй хамт түүнчлэн тэдгээрийг чи лацдах болно.

24 Учир нь болгоогтун, чиний бичих тэр хэлийг би будлиулсан; иймийн тул би өөрийн зохих цагт чиний бичих эдгээр зүйлүүдийг хүмүүсийн нүдэнд эдгээр чулуунууд тодруулахаар болгоно.

25 Мөн Их Эзэн эдгээр үгсийг хэлээд, тэрбээр Жаредын ахад, өмнө нь байсан дэлхийн “бүх оршин суугчдыг, мөн түүнчлэн цаашид байх бүгдийг үзүүлэв; мөн бүр дэлхийн төгсгөлийг хүртэлх тэднийг түүний нүднээс тэрбээр далдалсан нь үгүй.

26 “Хэрэв тэрээр өөрт нь ^битгэх аваас тэрээр түүнд “бүх зүйлийг үзүүлж чадна хэмээн тэрбээр түүнд өмнөх үед хэлсний учир — тэр нь түүнд үзүүлэгдэх болно, тиймийн тул тэрээр Их Эзэн өөрт нь бүгдийг үзүүлж чадна гэдгийг мэдсэн учир, Их Эзэн түүнээс юуг ч нууж чадсангүй ажээ.

27 Мөн Их Эзэн түүнд хандан хэлрүүн: Эдгээр зүйлийг бичигтүн мөн тэдгээрийг “лацдагтун; мөн би тэдгээрийг өөрийн зохих цагт хүмүүний үрст үзүүлэх болно.

28 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүлээж авсан “хоёр чулуугаа лацдаж, мөн Их

19а су Хөшиг.

20а Ифер 12:19–21.

21а Ифер 4:1.

23а су Урим ба Туммим.

25а Моце 1:8.

26а Ифер 3:11–13.

б су Итгэлтэй байх,

Итгэл.

в Ифер 4:4.

27а 2 Ниф. 27:6–8.

28а С ба Г 17:1.

Эзэн хүмүүний үрст үзүүлэх хүртэл тэдгээрийг үзүүлэхгүй байхыг Их Эзэн түүнд зарлиглав.

БҮЛЭГ 4

Жаредын ахын бичиглэлүүдийг лацдахаар Моронай зарлиг болгогдов— Хүмүүн бүр Жаредын ахынх шиг итгэлтэй болох хүртэл тэдгээр нь илчлэгдэхгүй— Христ өөрийнх нь үгсэд мөн түүний шавь нарынх нь үгсэд итгэхийг хүмүүнд зарлиглав— Хүмүүн наманчилж, сайн мэдээнд итгэж, мөн аврагдахаар зарлиг болгогдов.

Мөнхүү Их Эзэний дэргэдээс холдон уулнаас доошлон бууж, мөн үзсэн зүйлүүдээ “бичихийг Их Эзэн Жаредын ахад зарлиглав; мөн түүнийг загалмай дээр өргөгдсөний дарааг ⁶хүртэл хүмүүний үрсэд тэдгээрийн ирэх нь хориглогдов, мөн энэ шалтгааны улмаас Христ өөрийн хүмүүст өөрийгөө үзүүлэх хүртэл тэдгээр нь дэлхийд үл ирэхийн тулд Мозая хаан тэдгээрийг хадгалжээ.

2 Мөн Христ өөрийгөө үнэхээр өөрийн хүмүүст үзүүлсний дараа тэрээр тэдгээр нь илэрхийлэгдэхийг зарлиг болгов.

3 Мөн эдүгээ, түүний дараа, тэд бүгд итгэлгүйдээ бууран доройтсон ажээ; мөн лемен-

чүүдээс өөр хэн ч байсангүй, мөн тэд Есүс Христийн сайн мэдээг эсэргүүцэв; тиймийн тул тэдгээрийг дахин газарт “нуухаар би зарлиг болгогдов.

4 Болгоогтун, эдгээр ялтсууд дээр би Жаредын ахын үзсэн чухамхүү тэдгээр зүйлүүдийг бичсэн болой; мөн Жаредын ахад илэрхийлэгдсэн тэдгээрээс илүү агуу зүйлүүд хэзээ ч илэрхийлэгдэж байсангүй.

5 Иймийн тул тэдгээрийг бичихийг Их Эзэн надад зарлигласан; мөн би тэдгээрийг бичив. Мөн намайг тэдгээрийг “лацдахыг тэрээр зарлиг болгосон буюу; мөн тэрбээр тэдгээрийн хөрвүүлгийг түүнчлэн лацдахыг зарлиг болгосон; иймийн тул Их Эзэний зарлигийн дагуу, би ⁶хөрвүүлэгчдийг лацадсан билээ.

6 Учир нь Их Эзэн надад хандаж хэлрүүн: Тэд алдсаа наманчилж, мөн Их Эзэний өмнө цэвэр болох тэр өдрийг хүртэл тэдгээр нь харийнханд очихгүй.

7 Мөнхүү Их Эзэн өгүүлэн, тэд надаар “ариусгагдаж болохын тулд, бүр Жаредын ахын үйлдсэн лугаа адил, надад итгэх итгэлээ хэрэглэх тэр өдөр, тэгээд би бүр бүх илчлэлтүүдээ тэдэнд мэдүүлэх хүртэл Жаредын ахын үзсэн зүйлүүдийг илэрхийлэх болно хэмээн Есүс Христ,

4 1а Ифер 12:24.
су Судрууд.
б Ифер 3:21.
3а Морм. 8:14.

5а Ифер 5:1.
б С ба Г 17:1;
ИС—Т 1:52.
су Урим ба

Туммим.
7а су Ариусгал.

Бурханы Хүү, тэнгэр ба газрын мөн тэдгээрт буй бүх зүйлүүдийн ^бЭцэг хэлдэг бөлгөө.

8 Мөн Их Эзэний үгийн эсрэг “мэтгэлцэх тэр нь, тэрээр зүхэгдэг; мөн эдгээр зүйлийг ^бүгүйсгэх тэр нь, тэрээр зүхэгдэг; учир нь би тэдэнд ^илүү агуу зүйлийг үзүүлэх нь үгүй хэмээн Есүс Христ хэлдэг; учир нь ярьдаг тэр нь би бээр юм.

9 Мөн миний зарлигаар тэнгэр нээгдэж, мөн “хаагддаг; мөн миний үгээр ^бдэлхий чичирдэг; мөн миний зарлигаар түүний оршин суугчид галаар лугаа адил устгагдана.

10 Мөн миний үгсэд эс итгэх тэр нь миний шавь нарт итгэдэггүй; мөн намайг ярьсан эсэхийг, та нар шүүн тунгаагтун; учир нь “эцсийн өдөр, ярьж байсан нь би болохыг та нар мэдэх болно.

11 Гэвч миний ярьсан эдгээр зүйлсэд “итгэх, түүнд би Сүнснийхээ илэрхийлэлтээр айлчлах болно, мөн тэрээр мэдэж мөн гэрчлэх болно. Учир нь миний Сүнсний улмаас тэрээр эдгээр зүйлүүд ^бүнэнийг тэрээр ^имэднэ; учир нь энэ нь хүмүүсийг сайныг үйлдэхэд ятгадаг.

12 Мөн хүмүүсийг сайныг

үйлдэхэд ятгадаг аливаа зүйл нь надаас юм; “сайн нь надаас бус бол өөр хэнээс ч эс ирдгийн учир буюу. Хүмүүсийг сайн бүхний зүг хөтөлдөг чухамхүү тэр нь би юм; миний үгэнд ^бэс итгэх тэр нь надад — итгэхгүй байх болно; мөн надад итгэхгүй тэр нь намайг илгээсэн Эцэгт итгэхгүй байх болно. Учир нь болгоогтун, би бол Эцэг, би бол дэлхийн ^игэрэл ба ‘амь, мөн үнэн болой.

13 Надад “ирэгтүн, Ай харийнхан та нар, мөн би та нарт илүү агуу тэрхүү зүйлүүдийг, итгэлгүй байдлын улмаас далдлагдсан мэдлэгийг та нарт үзүүлэх болно.

14 Надад ирэгтүн, Ай Израилын угсаа та нар, мөн дэлхийн үүслээс, Эцэг та нарт бэлтгэсэн зүйлс ямар агуу болох нь та нарт “илэрхийлэгдэх болно; мөн итгэлгүй байдлын улмаас энэ нь та нарт мэдэгдээгүй буюу.

15 Болгоогтун, та нарын ёс бусын аймшигт байдалдаа, мөн сэтгэлийн хатуу, мөн оюуны харалгандаа үлдэх шалтгаан болж буй тэрхүү үл итгэх байдлын гивлүүрийг та нар тас татахад, тэгээд дэлхийн үүслээс эхлэн та нараас “нууцлагдаж байсан тэр агуу

7б Мозая 3:8.

8а 3 Ниф. 29:5–6;
Морм. 8:17.

б 2 Ниф. 27:14;
28:29–30.

в Алма 12:10–11;
3 Ниф. 26:9–10.

9а Хаад, дээд 8:35;
С ба Г 77:8.

б Хил. 12:8–18;
Морм. 5:23.

10а 2 Ниф. 33:10–15.
11а С ба Г 5:16.

б Ифер 5:3–4;
Моро. 10:4–5.

в су Гэрчлэл.
12а Алма 5:40;
Моро. 7:16–17.

б 3 Ниф. 28:34.

в су Гэрэл, Христийн гэрэл.

г Иохан 8:12;
Алма 38:9.

13а 3 Ниф. 12:2–3.

14а С ба Г 121:26–29.
15а 2 Ниф. 27:10.

мөн гайхамшигт зүйлийг, тийм ээ, та нар харууссан зүрх мөн гэмшсэн сэтгэлтэйгээр, миний нэрээр, Эцэгт хандан залбирахад, тэгэхэд Ай Израилын угсаа, та нарын эцэг өвгөдтэй хийсэн гэрээгээ Эцэг санасныг та нар мэдэх болно.

16 Мөн тэгээд би өөрийн үйлчлэгч Иоханаар бичүүлсэн миний “илчлэлтүүд бүх хүмүүсийн нүдний өмнө дэлгэгдэх болно. Санагтун, та нар эдгээр зүйлийг харахдаа, тэдгээр нь чухамхүү бодит байдлаар үзүүлэгдэх цаг ойрхон ирээд буйг та нар мэдэх болно.

17 Тиймийн тул, та нар энэ цэдгийг “хүлээн аваад Эцэгийн ажил уг нутгийн бүх гадаргуу дээр эхэлсэн болохыг та нар мэдэж болно.

18 Тиймийн тул, дэлхийн бүх хязгаарууд та нар “наманчлагтун, мөн надад ирэгтүн, мөн сайн мэдээнд минь итгэгтүн, мөн миний нэрээр ^ббаптисм хүртэгтүн; учир нь итгэн мөн баптисм хүртсэн нь аврагдах болно; гэвч үл итгэх тэр нь яллагдах болно; мөн миний нэрэнд итгэх тэднийг ^втэмдгүүд дагалдах болно.

19 Мөн эцсийн өдөр миний

нэрэнд “итгэлтэй хэвээр байх адислагдсан болой, учир нь тэр нь дэлхийн ^бүүслээс түүнд зориулагдан бэлтгэгдсэн хаант улсад оршин байхаар тэр өргөгдөх болно. Мөн болгоогтун үүнийг ярьсан нь би болой. Амен.

БҮЛЭГ 5

Гурван гэрч хийгээд уг ажил нь өөрөө Мормоны Ном үнэний гэрчлэл болон зогсоно.

Мөн эдүгээ би, Моронай, ой ухааныхаа дагуу, надад зарлиг болгосон үгсийг бичсэн буюу; мөн би “лацадсан зүйлүүдээ танд хэлсэн бөлгөө; тиймийн тул та нар орчуулж болно хэмээн тэдгээрийг бүү хөндөгтүн; учир нь хэзээ нэгэн цагт энэ нь Бурханы мэргэн ухаанд байхаас бусдаар, тэр зүйл та нарт хориглогдсон болой.

2 Мөн болгоогтун, энэ ажлыг авчрахад тулах “тэдэнд уг ялтсуудыг та нар үзүүлж болно хэмээн та нар эрх авч магадгүй юм;

3 Мөн Бурханы хүчээр “гуравт тэдгээр нь үзэгдэх болно; иймийн тул тэд эдгээр зүйлүүд ^бүнэнийг гарцаагүйгээр ^вмэдэх болно.

16a Илч. 1:1;

1 Ниф. 14:18–27.

17a 3 Ниф. 21:1–9, 28.

18a 3 Ниф. 27:20;

Моро. 7:34.

б Иохан 3:3–5.

сү Баптисм, Баптисм хүртээх нь—Чухал шаардлага.

в сү Сүнсний бэлгүүд.

19a Мозая 2:41;

С ба Г 6:13.

сү Есүс Христ—

Өөрсөд дээрээ Есүс Христийн нэрийг авах.

б 2 Ниф. 9:18.

5 1a 2 Ниф. 27:7–8, 21; Ифер 4:4–7.

2a 2 Ниф. 27:12–14;

С ба Г 5:9–15.

3a 2 Ниф. 11:3; 27:12.

б Ифер 4:11.

в С ба Г 5:25.

4 Мөнхүү гурван “гэрчийн амаар эдгээр зүйлүүд нотлогдох болно; мөн гурвын гэрчлэл, мөн ажил, түүгээр Бурханы хүч, мөн түүнчлэн Эцэг, мөн Хүү, мөн Ариун Сүнс гэрчлэх түүний үг үзүүлэгдэх тэр— мөн энэ бүхэн нь эцсийн өдөр дэлхийнхний эсрэг гэрчлэл болон зогсох болно.

5 Мөн хэрэв тэд наманчилж мөн Есүсийн нэрээр Эцэгт “ирэх аваас, тэд Бурханы хаант улсад хүлээн авагдах болно.

6 Мөн эдүгээ, хэрэв эдгээр зүйлүүдэд надад эрх мэдэл буй ээхийг, та нар шүүн тунгаагтун; учир нь намайг харахад надад эрх мэдэл буйг та нар мэдэх болно, мөн бид эцсийн өдөр Бурханы өмнө зогсох болно. Амен.

БҮЛЭГ 6

Жаредчуудын хөлгүүд салхинд туугдан амлагдсан нутагт хүрэв— Сайн сайхных нь учир хүмүүс Их Эзэнийг магтан дуулав— Ораиха тэдний дээр хаан болохоор томилогдов— Жаред болон түүний ах нас эцэслэв.

Мөн эдүгээ, би, Моронай, Жаред болон түүний ахын цэдгийг үргэлжлүүлсүгэй.

2 Учир нь улиран тохиох дор уул өөд Жаредын ахын

өргөж гаргасан “чулуунуудыг бэлтгэсний дараа, Жаредын ах уулан дээрээс буун ирж, мөн тэрээр бэлтгэгдсэн хөлгүүд дотроо уг чулуунуудыг Их Эзэн хоёр үзүүрт нь нэг нэгийг тавьжээ; мөн болгоогтун, тэдгээр нь хөлгүүдэд гэрэл өгсөн ажээ.

3 Мөн тийн Их Эзэн чулуунуудыг харанхуйд гэрэлтэн, эрчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүдэд, тэд их усыг харанхуйд гатлахгүй байж болохын тулд, гэрэл өгөх болгосон бөлгөө.

4 Мөнхүү улиран тохиох дор тэд усан дээр амь зууж болохын тулд, тэд бүхий л төрлийн хоол ундыг, мөн бог болон бод малдаа хүнс тэжээлийг мөн өөрсөдтэйгөө авч явах ёстой аливаа амьтан жигүүртнийг бэлтгээд— мөнхүү улиран тохиох дор эдгээр бүх зүйлийг гүйцэлдүүлснийхээ дараа тэд хөлөг онгоц мөн усан онгоцон дээрээ гарцгаан, мөн өөрсдийгөө Их Эзэн Бурхандаа даатгаад, далайд хөвж одов.

5 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Бурхан, амлагдсан нутгийн зүг усан дээгүүр “ширүүн салхи үлээж байхаар болгосон аж; мөн тийн тэд салхины өмнө далайн давалгаанд шидэгдэн явав.

6 Мөнхүү улиран тохиох дор тэдний дээр задрах уулс мэт давалгаанууд, мөн түүнчлэн

4a С ба Г хэсэг 17-гийн оршил хэсэг болон шүлэг 1-3-ыг үз; Мормоны Номны

өмнөх үгийн хуудсууд дахь Гурван гэрчийн гэрчлэлийг мөн үз.

5a Морм. 9:27; Моро. 10:30–32.
6 2a Ифер 3:3–6.
5a Ифер 2:24–25.

салхины догшноос үүссэн агуу хийгээд аймшигт их шуургануудаас болон далайн гүнд тэд олонтаа автагдсан бөлгөө.

7 Мөнхүү улиран тохиох дор тэдний хөлөг таваг лугаа адил “нягт, мөн тэд Ноагийн ^бхөлөг онгоц лугаа адил нягт байсан тул гүнд автагдахад нь ус тэднийг огтхон ч гэмтээж эс чадав; тиймийн тул тэд их усанд хучигдсан үедээ Их Эзэнд залбиран гуйж, мөн тэрбээр тэднийг дахин усны мандал дээр гаргаж байв.

8 Мөнхүү улиран тохиох дор тэднийг усны мандал дээр байх үест салхи амлагдсан нутаг тийш үлээхээ хэзээ ч зогссонгүй; мөн тийн тэд салхины өмнө урагш туугдсан авай.

9 Мөн тэд Их Эзэнийг “магтан дуулж байв; тийм ээ, Жаредын ах Их Эзэнийг магтан дуулсан буюу, мөн тэрээр бүх л өдрийн турш Их Эзэнд ^бталархан мөн магтаж байв, мөн шөнө болоход, тэд Их Эзэнийг магтахаа зогссонгүй.

10 Мөн тийн тэд урагш туугдаж байв; мөн далайн ямар ч мангас тэднийг сүйтгэж, ямар ч халим тэднийг гэмтээж чадсангүй; мөн тэд усан дээр ч, мөн усан дор ч байсан тэд үргэлжид гэрэлтэй байлаа.

11 Мөн тийн тэд гурван зуун

дөчин дөрвөн өдөр усан дээр урагш туугджээ.

12 Мөн тэд амлагдсан нутгийн эрэгт газардав. Мөн амлагдсан нутгийн эрэгт тэд хөл тавиад, тэдэнд түүний үзүүлсэн эрхэм их нигүүлслийн улмаас, тэд газрын гадаргуу доош өөрсдөө мэхийн, мөн Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусган, мөн Их Эзэний өмнө баяр хөөрийн нулимс дуслуулсан бөлгөө.

13 Мөнхүү улиран тохиох дор тэд нутгийн гадаргуу дээгүүр явж, мөн газраа боловсруулж эхлэв.

14 Мөн Жаред дөрвөн хүүтэй болов, мөн тэд Жеком, мөн Гилга, мөн Маха, мөн Ораиха хэмээн нэрлэгдсэн бөлгөө.

15 Мөн Жаредын ах нь түүнчлэн хөвгүүд охидтой болсон ажгуу.

16 Мөн Жаредын мөн түүний ахын “найзууд хорин хоёр тооны бодгаль байлаа; мөн тэд түүнчлэн амлагдсан нутагт ирэхийнхээ өмнө хөвгүүд охидыг төрүүлсэн бөлгөө; мөн тиймийн тул тэд олон болж эхлэв.

17 Мөн тэд Их Эзэний өмнө даруухнаар “алхахыг заалгав; мөн тэд дээрээс түүнчлэн ^бзаалгасан байв.

18 Мөнхүү улиран тохиох дор тэд нутгийн гадаргуу дээгүүр тархаж, мөн үржиж мөн газраа боловсруулж эхлэн; мөн нутагтаа тэд хүчирхэгжжээ.

7а Ифер 2:17.

б Эхл. 6:14; Мосе 7:43.

9а су Дуулах.

б Шаст. дээд 16:7–9;

Алма 37:37;

С ба Г 46:32.

16а Ифер 1:41.

17а су Алхах,

Бурхантай хамт алхах.

б су Илчлэлт.

19 Мөн Жаредын ах нь өтөлж эхлэн, мөн тэр удахгүй доош булшинд орохоор явах ёстойгоо ухаарсан аж; иймийн тул тэр Жаредад хандан хэлрүүн: Бид тэднийг тоолон, түүнчлэн биднийг булшиндаа орохоос өмнө тэд биднээс юу хүсэхийг нь тэднээс бид мэдэж болохын тулд өөрсдийн хүмүүсийг цуглуулцгаая.

20 Мөн тийн хүмүүс нэгдэн цуглуулагдав. Эдүгээ Жаредын ахын хөвгүүд болоод охидын тоо хорин хоёр бодгаль байв, мөн Жаредын хөвгүүд охидын тоо арванхоёр байв, тэрбээр дөрвөн хүүтэй байв.

21 Мөнхүү улиран тохиох дор тэд өөрсдийн хүмүүсийг тоолов; мөн тийн тэднийг тоолсныхоо дараа, тэд булшиндаа орохоос өмнө тэднийг юу хийгээсэй хэмээн хүсч буйг нь тэднээс асуув.

22 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс хөвгүүдийнхээ нэгийг тэдний дээр хаан байхаар “тослогдохыг тэднээс хүсэв.

23 Мөн эдүгээ болгоогтун, энэ нь тэдэнд эмгэнэлтэй байв. Мөн Жаредын ах тэдэнд хандан хэлрүүн: Энэ зүйл боолчлолд гарцаагүй “хөтлөх болно.

24 Гэвч Жаред ахдаа хандан хэлрүүн: Тэд хаантай байж болохыг тэдэнд зөвшөөрөгтүн. Мөн гиймийн тул тэрээр тэдэнд хэлсэн нь: Хөвгүүдийн

маань дундаас бүр өөрсдийн хүссэнээ хаан болгон сонгогтун.

25 Мөнхүү улиран тохиох дор тэд бүр Жаредын ахын ууганыг нь сонгов; мөн түүний нэр Пегог байв. Мөнхүү улиран тохиох дор тэрээр татгалзаж мөн тэдний хаан болохгүй хэмээв. Мөн хүмүүс эцэг нь түүнийг албадаасай хэмээсэн аж, гэвч эцэг нь тэгэхээс татгалзав; мөн өөрсдийнхөө хаан болгох гэж тэд нэг ч хүмүүнийг албадах ёсгүйг тэрээр тэдэнд зарлиглав.

26 Мөнхүү улиран тохиох дор тэд Пегогийн бүх дүү нарыг сонгосон ч, мөн тэд тэгэхээс татгалзав.

27 Мөнхүү улиран тохиох дор Жаредын хөвгүүд ч бас, ганцаас бусад нь, бүр бүгд тэгэхээс татгалзсан буюу; мөн Ораиха хүмүүсийн дээр хаан нь байхаар тослогдсон ажгуу.

28 Мөн тэр засаглаж эхлэв, мөн хүмүүс дэгжиж эхлэв; мөн тэд үлэмж баян болцгоосон бөлгөө.

29 Мөнхүү улиран тохиох дор Жаред, мөн түүний ах ч нас нөгчив.

30 Мөнхүү улиран тохиох дор Ораиха Их Эзэний өмнө даруухнаар алхаж байв, мөн Их Эзэн түүний эцгийнх нь төлөө ямар агуу зүйлүүд үйлдсэнийг санаж, мөн түүнчлэн Их Эзэн тэдний эцэг өвгөдийн төлөө ямар агуу зүйлүүд үйлдсэнийг

өөрийн хүмүүст сургасан бөлгөө.

БҮЛЭГ 7

Ораиха зөв шударга байдалд засаглав—Засгийн эрхийг хүчээр булаах хийгээд зөрчил сөргөлдөөний дунд, Шуле мөн Кохорын өрсөлдөгч хаант улсууд байгуулагдав—Бошиглогчид хүмүүсийн ёс бусын үйл мөн хиймэл шүтээн шүтэхийг буруушааж, тэгээд тэд наманчилцаав.

Мөнхүү улиран тохиох дор Ораиха өөрийн бүх өдрүүдэд зөв шударга байдлаар нутгийн дээр хууль цаазыг хэрэгжүүлсэн бөлгөө, өдрүүд нь үлэмж олон байсан буюу.

2 Мөн тэрбээр хөвгүүд мөн охидтой болов; тийм ээ, тэрбээр гучин нэгийг төрүүлэв, тэдний дунд хорин гурав нь хөвгүүн байв.

3 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр өндөр насандаа Кибийг төрүүлэв. Мөнхүү улиран тохиох дор түүний сууринд Киб засаглав; мөн Киб Корихорыг төрүүлэв.

4 Мөн Корихор гучин хоёр насандаа тэрбээр эцгээ эсэргүүцэн босов, мөн явж Нихорын нутагт очиж суурьшив; мөн тэрбээр хөвгүүд мөн охидыг төрүүлж, мөн тэд үлэмж хонгорхон болов; иймийн тул Корихор олон хүмүүнийг араасаа дагуулсан болой.

5 Мөн тэрбээр их цэргийг нэгтгэн цуглуулаад, тэрбээр

хааны суурьшиж асан Мороны нутагт ирж, мөн түүнийг олзлон авсан нь Жаредын ахын “хэлсэн тэд боолчлолд хөтлөгдөх болно хэмээсэн үгийг улируулан тохиолгосон буюу.

6 Эдүгээ хааны суурьшиж асан Мороны нутаг нь Эзгүйрэл хэмээн нифайчуудаар нэрлэгдсэн нутгийн ойр байв.

7 Мөнхүү улиран тохиох дор Киб тэрбээр үлэмж өндөр насыг зооглох хүртлээ боолчлолд байж, мөн түүний хүмүүс түүний хүү Корихорын мэдэлд байв; гэсэн хэдий ч Киб өндөр насандаа, тэрбээр боолчлолд байх үедээ Шулег төрүүлэв.

8 Мөнхүү улиран тохиох дор Шуле ахдаа уурлаж байв, мөн Шуле хүч тэнхээтэй болж, мөн хүмүүний хүч чадлаар бол хүчит нэгэн болов; мөн тэрээр бас шүүн тунгаахдаа ч хүчит нэгэн байв.

9 Иймийн тул, тэрбээр Ефраимын гүвээн дээр ирэн, мөн тэрбээр гүвээнээс хайлуулан аваад, мөн өөрийн хамт дагуулсан тэдэнд зориулан гангаар илднүүд хийв; мөн тэднийг илдээр зэвсэглэснийхээ дараа тэрээр Нихор хотод эргэн ирж, мөн өөрийн ах Корихортой тулалдаанд орж, түүгээрээ тэрбээр хаант улсыг эзлэн авч мөн түүнийг эцэг Кибтээ сэргээн өгсөн бөлгөө.

10 Мөн эдүгээ Шулегийн

хийсэн зүйлийн улмаас, түүний эцэг түүнд хаант улсаа өгөв; тиймийн тул тэрээр эцгийнхээ сууринд засаглаж эхлэв.

11 Мөнхүү улиран тохиох дор тэрээр зөв шударга байдлаар хууль цаазыг хэрэгжүүлсэн буюу; мөн хүмүүс үлэмж их тоотой болны учир тэрбээр хаант улсаа нутгийн бүх гадаргуу дээгүүр өргөжүүлэв.

12 Мөнхүү улиран тохиох дор Шуле түүнчлэн олон хөвгүүд охид төрүүлэв.

13 Мөн Корихор өөрийн үйлдсэн олон хилэнцэт үйлүүдээ наманчлав; иймийн тул Шуле хаант улсдаа түүнд хүчийг олгов.

14 Мөнхүү улиран тохиох дор Корихор олон хөвгүүд мөн охидтой байв. Мөн Корихорын хөвгүүдийн дунд Ноа хэмээх нэртэй нэгэн байв.

15 Мөнхүү улиран тохиох дор Ноа, Шуле хааны, мөн түүнчлэн өөрийн эцэг Корихорын эсрэг босож, мөн ах Кохорыгоо, мөн түүнчлэн өөрийн бүх ах дүүсийг мөн хүмүүсээс олныг дагуулав.

16 Мөн тэрбээр, хаан Шулегийн эсрэг тулаанд орж, тэгснээр тэдний анхных нь өвийн нутгийг эзэлж авав; мөн тэрбээр тэр нутгийн тэр хэсгийн дээр хаан болов.

17 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр, хаан Шулегийн эсрэг дахин тулалдаанд оров; мөн тэрбээр, хаан Шулег авч, мөн түүнийг Морон тийш олзлон аваачжээ.

18 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр түүнийг үхэлд хүргэх гэж байхад нь, Шулегийн хөвгүүд Ноагийн байшинд шөнөөр нэвтрэн орж мөн түүнийг хөнөөгөөд, мөн шоронгийн хаалгыг нураан мөн эцгээ гаргаж авав, мөн өөрийнх нь хаант улсын сэнтийд түүнийг залав.

19 Иймийн тул, Ноагийн хүү түүний оронд өөрийн хаант улсыг өргөтгөжээ; гэсэн хэдий ч тэд хаан Шулегийн дээр цаашид хүчийг олоогүй буюу, мөн хаан Шулегийн засаглалд байсан хүмүүс үлэмж дэгжиж мөн агуу болцгоов.

20 Мөнхүү гүрэн хуваагдав; мөн тэнд хоёр хаант улс, Шулегийн хаант улс, мөн Ноагийн хүү Кохорын хаант улс байх болов.

21 Мөн Ноагийн хүү, Кохор өөрийн хүмүүсийг Шулегийн эсрэг тулаанд оруулж, тэгснээр Шуле тэднийг бут цохин мөн Кохорыг хөнөөв.

22 Мөн эдүгээ Кохор Нимрод хэмээн нэрлэгдсэн хүүтэй байв; мөн Нимрод Кохорын хаант улсыг Шулед өгөв, мөн тэрбээр Шулегийн нүдэнд тааллыг олов; иймийн тул Шуле түүнд агуу хайр хишиг хүртээж, мөн Шулегийн хаант улсад өөрийнхөө хүслээр тэр үйлдсэн буюу.

23 Мөн түүнчлэн Шулегийн засаглалд, хүмүүсийн дунд бошиглогчид ирэв, Их Эзэнээс илгээгдсэн тэд, хүмүүсийн ёс бусын үйл мөн “хиймэл

шүтээнийг шүтэх нь уг нутагт зүхлийг авчирч буй, мөн хэрэв тэд эс наманчлах аваас тэд устгагдах болно хэмээн бошиглосон ажээ.

24 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс бошиглогчдыг доромжлон, мөн тэднийг элэглэв. Мөнхүү улиран тохиох дор хаан Шуле бошиглогчдыг доромжилсон тэд бүгдийн эсрэг хууль цаазыг хэрэгжүүлсэн аж.

25 Мөн тэрбээр бүх газар нутгаар хуулийг хэрэгжүүлсэн нь бошиглогчдод хаа хүссэн газраа явах хүчийг олгосон ажгуу; мөн энэ шалтгааны улмаас хүмүүс наманчлалд хүргэгдэв.

26 Мөн хүмүүс өөрсдийн алдсууд болоод хиймэл шүтээнүүдийг шүтэхээ наманчилсан учир Их Эзэн тэднийг хэлтрүүлж, мөн тэд уг нутагт дахин дэгжиж эхлэв. Мөнхүү улиран тохиох дор Шуле өндөр насандаа хөвгүүд мөн охидыг төрүүлэв.

27 Мөн Шулегийн өдрүүдэд дахин дайн байсангүй; мөн тэрбээр, амлагдсан газарт агуу гүнийг “гаталган авчирснаар Их Эзэн эцэг өвгөдийнх нь төлөө хийсэн агуу зүйлийг сана; иймийн тул тэрбээр өөрийн бүх өдрүүдэд зөв шударга ёсоор хууль цаазыг хэрэгжүүлсэн бөлгөө.

БҮЛЭГ 8

Хаант улсын талаар зөрчил сөргөлдөөн үүсэв—Хааныг хөнөөхөөр

тангарагт нэгдсэн нууц хуйвалдааныг Акиш байгуулав—Нууц хуйвалдаанууд чөтгөрийнх бөгөөд үр дүн нь үндэстнүүдийг устгалд хүргэдэг—Орчин цагийн харийнхан бүх нутгийн, үндэстний, мөн улсуудын эрх чөлөөг булаан авахаар тэмүүлэх нууц хуйвалдааны эсрэг сэрэмжлүүлэгдсэн буюу.

Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Омерыг төрүүлж, мөн Омер түүний оронд засаглав. Мөн Омер Жаредыг төрүүлэв; мөн Жаред хөвгүүд болоод охидыг төрүүлэв.

2 Мөн Жаред эцгийнхээ эсрэг босч, мөн Хетийн нутагт ирж мөн суурьшив. Мөнхүү улиран тохиох дор тэрбээр хаант улсын хагасыг эзэгнэх хүртлээ, тэрбээр башир үгсийнхээ учир, олон хүнийг тэрбээр зусардав.

3 Мөн тэр хаант улсын хагасыг эзэгнээд эцгийнхээ эсрэг тэрээр тулалдаанд орж, мөн тэрээр эцгээ олзлон авч одов, мөн түүнийг боолчлолд үйлчлүүлэх болгов;

4 Мөн эдүгээ, Омерын засаглалын өдрүүдэд, өөрийн өдрүүдийн хагаст тэрээр боолчлолд байв. Мөнхүү улиран тохиох дор тэрбээр хөвгүүд мөн охидыг төрүүлж, тэдний дунд Изром мөн Кориантумр нар байв.

5 Мөн тэд өөрсдийн ах Жаредын үйлийн улмаас үлэмж хилэгнэн, үүний хэрээр тэд их цэрэг босгон мөн Жаредын эсрэг тулалдаанд оров. Мөнхүү улиран тохиох дор

тэд түүний эсрэг шөнөөр тулалдаанд орсон ажээ.

6 Мөнхүү улиран тохиох дор тэд Жаредын их цэргийг хөнөөчихөөд түүнчлэн түүнийг ч хөнөөх гэж байв; мөн тэрбээр өөрийг нь үл хөнөөх аваас тэрбээр хаант улсаа эцэгтээ өгөх болно хэмээн тэднээс гуйв. Мөнхүү улиран тохиох дор тэд түүний амийг хэлтрүүлсэн ажгуу.

7 Мөн эдүгээ Жаред хаант улсынхаа алдагдлын улмаас, тэрбээр зүрх сэтгэлээ хаант улсдаа мөн дэлхийн алдар хүндэд байрлуулсны учир үлэмж харуусав.

8 Эдүгээ Жаредын охин үлэмж сэргэлэн зальтай, мөн эцгийнхээ харууслыг хараад, тэрбээр хаант улсыг эцэгтээ сэргээж өгөх төлөвлөгөө боловсруулахыг бодов.

9 Эдүгээ Жаредын охин үлэмж хонгорхон байв. Мөнхүү улиран тохиох дор тэрээр эцэгтэйгээ ярьж, мөн түүнд хандан өгүүлсэн нь: Юунд эцэг минь ийм их харуусалтай байна вэ? Агуу гүнийг гатлан өвөг дээдсийн минь авчирсан цэдгийг тэрээр эс уншсан юм гэж үү? Болгоогтун, тэд өөрсдийн “нууц төлөвлөгөөгөөр хаант улс хийгээд агуу алдар сууг тээгнэсэн эртний тэдний талаар шастир үгүй гэж үү?

10 Мөн эдүгээ, тиймийн тул, Кимнорын хүү Акишт эцэг минь илгээг; мөн болгоогтун,

бибээр хонгорхон, мөн би түүний өмнө “бүжиглэж, мөн би түүнийг баярлуулснаас тэрээр намайг эхнэрээ болгохыг хүсэх болно; иймийн тул хэрэв тэрээр танаас намайг түүнд эхнэр болгон өгөхийг хүсэх аваас, тэгвэл та түүнд хэлэгтүн: Хэрэв та миний эцэг, хааны толгойг надад авчрах аваас би түүнийг танд өгөх болно.

11 Мөн эдүгээ Омер Акишт анд нь байв; иймийн тул, Жаред Акишийг дуудаад, Жаредын охин түүний өмнө бүжиглэснээр түүнийг баярлуулж, чингээд тэрээр түүнийг эхнэрээ болгохыг хүсэв. Мөнхүү улиран тохиох дор тэрээр Жаредад хандан хэлсэн нь: Надад түүнийг эхнэр болгон өгөгтүн.

12 Мөн Жаред түүнд хандан: Хэрэв та надад миний эцэг, хааны толгойг авчирч өгөх аваас би түүнийг танд өгье хэмээн хэлжээ.

13 Мөнхүү улиран тохиох дор Акиш Жаредын гэрт түүний бүх төрлийнхнийг цуглуулан, мөн тэдэнд хэлсэн нь: Би та нараас хүсэх зүйлд та нар үнэнч байхаа надад андгайлах уу?

14 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгдээрээ түүнд тэнгэрийн Бурханаар, мөн бас тэнгэрүүдээр, мөн түүнчлэн газар дэлхийгээр, мөн өөрсдийнхөө толгойгоор, хэн нэг нь Акишийн хүссэн туслам-

жийг үзүүлэхгүй аваас тэр толгойгоо алдана; мөн Акишийн тэдэнд мэдэгдсэн ямарваа зүйлийг илрүүлсэн хэн боловч, мөнхүү тэр нь амиа алдах болно хэмээн түүнд “андгайлав.

15 Мөнхүү улиран тохиох дортийн тэд Акиштай зөвшилцөв. Мөн Акиш эхлэлээс алуурчин байв бүр “Каинаас доош гардагдсан тэр хүч чадлыг түүнчлэн эрэлхийлсэн эртний тэднээр өгөгдсөн ^бтангаргийг тэднээр хэлүүлсэн ажгуу.

16 Мөн эдгээр тангаргууд хүмүүст хэлэгдэхээр, тэднийг харанхуйд үлдээхийн тулд, хүчийг эрэлхийлэх түүнд хүчийг олж авахад, мөн хүн алахад, мөн тоноход, мөн худал хэлэхэд, мөн бүх л төрлийн ёсон бус үйлэнд мөн садар самууныг хийхэд туслахын тулд чөтгөрийн хүч чадлаар хадгалагдан үлдээгдсэн бөлгөө.

17 Мөн эртний эдгээр зүйлийг хайхыг түүний зүрх сэтгэлд суулгасан тэр бол Жаредын охин байв; мөн Жаред үүнийг Акишийн зүрх сэтгэлд суулгасан ажээ; иймийн тул, Акиш үүнийг түүний төрөл мөн нөхдөөр хэлүүлж, өөрийн хүссэн бүх зүйлийг хийхээр дур булаам амлалтаар тэднийг удирдан дагуулжээ.

18 Мөнхүү улиран тохиох дор

тэд яг л эртнийх лугаа адил, нууц “хуйвалдааныг, Бурханы мэлмийд хамгийн жигшүүрт мөн ёс бус болох хуйвалдааныг бий болго.

19 Учир нь Их Эзэн нууц хуйвалдаанаар ажиллах нь үгүй, бас хүмүүн цусаа урсгахыг тэр таалах нь үгүй, харин бүх зүйл дээр түүнийг хүмүүний эхлэлээс хориглосон билээ.

20 Мөн эдүгээ би, Моронай, тэдний тангаргийн мөн хуйвалдаануудын аргыг эс бичнэм, учир нь тэдгээр нь бүх хүмүүсийн дунд байдаг, мөн тэдгээр нь леменчүүдийн дунд байгаа нь надад мэдүүлэгдсэн болой.

21 Мөн тэдгээр нь миний одоо тухайлан ярьж буй эдгээр хүмүүсийн “устгалын, мөн түүнчлэн Нифайн хүмүүсийн устгалын шалтгаан болсон юм.

22 Мөн хүчийг олж мөн хөрөнгө хураахаар, нууц хуйвалдаанууд тэр үндэстнийг эзэгнэх болтол тэдгээрийг дэмжих ямарваа үндэстэн, болгоогтун, тэд устгагдах болно; учир нь тэдний урсгах өөрийнх нь гэгээнтнүүдийн “цус нь тэднээс өс хонзон авахуулахаар газраас өөрт нь хандан үргэлж гуйхыг мөн өөрөө ^бөс хонзонг тэднээс авахгүй байхыг Их Эзэн хүлцэх бөлгөө.

23 Иймийн тул, эдгээр зүй-

14a су Доромжлох,
Доромжлол.
15a Эхл. 4:7–8;
Моисе 5:28–30.

б су Тангараг.
18a су Нууц
хуйвалдаанууд.
21a Хил. 6:28.

22a Морм. 8:27, 40–41.
б су Өс хонзон.

лүүд та нарт үзүүлэгдэх нь Бурханы мэргэн ухаан Ай харийнхан та нар, тэгснээр та нар нүглээ наманчилж, мөн “хүчийг олж мөн хөрөнгө хураахын тулд байгуулагдсан эдгээр аллагын хуйвалдаанууд өөрсдийн тань дээр давж гарахыг — мөн уг ажил, тийм ээ, бүр устгалын ажил өөрсдийн дээр чинь ирэхийг зөвшөөрөхгүй байж болно, тийм ээ, хэрэв та нар эдгээр зүйлүүдийг оршихыг зөвшөөрөх аваас, та нарын уналт мөн устгалд хүргэх, бүр Мөнхийн Бурханы шударга ёсны илд та нарын дээр буух болно.

24 Иймийн тул, та нарын дунд эдгээр зүйлүүд ирэхийг та нар үзэх үед, та нарын дунд орших энэ нууц хуйвалдааны улмаас, өөрсдийн аймшигт байдлынхаа мэдрэмжинд та нар сэрэгтүн хэмээн Их Эзэн та нарт зарлиг болгосон билээ; эс бөгөөс алагдсан тэдний цусны улмаас, үүнд халаг болог; учир нь тэд үүний дээр, мөн түүнчлэн үүнийг бий болгосон тэдний дээр өс хонзон авалт ирүүлэхийн тул газар шорооноос гүйх буюу.

25 Учир нь улиран тохиох дор үүнийг бий болгох хэн боловч бүх нутгуудын, үндэстнүүдийн, мөн улсуудын “эрх чөлөөг булаан авахаар эрэлхийлдэг мөн энэ нь бүх

хүмүүсийн устгалыг улируулан тохиолгодог, учир нь энэ нь бүх худал хуурмагийн эцэг; бүр бидний анхны эцэг эхийг ^бхуурсан тэрхүү худалч, тийм ээ, бүр эхлэлээс эхлэн хүмүүнийг аллага үйлдэх болгосон; тэд бошиглогчдыг алан, мөн тэднийг чулуугаар шидсэн, мөн эхлэлээс эхлэн тэднийг хөөн гаргах болгож хүмүүсийн зүрх сэтгэлийг хатууруулсан мөнхүү тэр худалч болох чөтгөрөөр бий болгогдсон юм.

26 Иймийн тул, хилэнцэт үйл зогсоогдож болох, мөн хүмүүний үрсийн зүрх сэтгэлд Сатан ямар ч “хүчийг агуулж үл чадах, харин тэд үргэлжлүүлэн сайныг хийхээр ^бятгагдаж болох, тэд бүх л зөв шударгын эх булагт ирж мөн аврагдаж болох тэр цаг ирж болохын тулд би, Моронай, эдгээр зүйлүүдийг бичихээр зарлиг болгогдсон билээ.

БҮЛЭГ 9

Хаант улс нэгээс нөгөөд удмаар, хуйвалдаанаар, мөн аллагаар дамжив—Имер Зөв Шударгын Хүүг харав—Олон бошиглогч наманчлалыг номлов—Өлсгөлөн мөн хорт могойнууд хүмүүсийг нэрвэв.

Мөн эдүгээ, би, Моронай, цэдгээ үргэлжлүүлье. Тий-

23a 1 Ниф. 22:22–23;
Моце 6:15.

25a су Эрх чөлөө, Эрх чөлөөт.

б Эхл. 3:1–13;
2 Ниф. 9:9;
Мозая 16:3;
Моце 4:5–19.

26a 1 Ниф. 22:26.
б 2 Ниф. 33:4;
Моро. 7:12–17.

мийн тул, болгоогтун, мөнхүү улиран тохиох дор Акиш мөн түүний найзуудын “нууц хуйвалдаануудын улмаас, болгоогтун, тэд Омерын хаант улсыг булаан авав.

2 Гэсэн хэдий ч, Их Эзэн Омерт нигүүлсэнгүй байв, мөн түүнчлэн, түүний хөвгүүд хийгээд охидынх нь устгалыг эрэлхийлсэнгүй.

3 Мөн Омерт зүүдэнд нь уг нутгаас гарч одохыг Их Эзэн сэрэмжлүүлэв; иймийн тул Омер гэр бүлийнхээ хамт нутгаас гарч одон, мөн олон өдөр аялж, мөн “Шимийн толгойд ирэн мөн хажуугаар нь өнгөрч, мөн ^бнифайчуудын устгагдсан тэр газрын ойролцоо ирэв, мөн тэндээс зүүн тийш, мөн тэнгисийн эргийн дагуух, Аблом гэж нэрлэгдэх газар ирэв, мөн тэрээр тэнд майхнаа босгов, мөн түүнчлэн Жаред болон түүний гэр бүлээс бусад, түүний хөвгүүд мөн охид нь, мөн түүний бүх гэрийнхэн нь буюу.

4 Мөнхүү улиран тохиох дор Жаред хүмүүсийн дээр, ёс бусын гараар тослогдсон хаан болов; мөн тэр Акишт охиноо эхнэр болгон өгөв.

5 Мөнхүү улиран тохиох дор Акиш хадам эцгийнхээ амийг эрэлхийлэв; мөн тэрээр эртнийхний тангаргаар андгайлсан тэдэндээ хандав; мөн тэд, тэрээр хаан ширээнээ заларч, өөрийн хүмүүсийг хүлээн авч байхад

нь хадам эцгийнх нь толгойг авав.

6 Учир нь, энэхүү ёс бус мөн нууц нийгэмлэгийн тархалт бүх хүмүүсийн зүрх сэтгэлийг эзлэх болтлоо тийм агуу байлаа; тиймийн тул Жаред хаан ширээндээ алагдан, мөн Акиш түүний оронд засаглав.

7 Мөнхүү улиран тохиох дор Акиш хүүдээ атаархаж эхлэн, тиймийн тул тэрээр түүнийг шоронд хорин, мөн түүнийг өчүүхэн хоолтойгоор эсвэл огт хоолгүйгээр үхэлтэй учрах хүртэл нь тэрээр үлдээсэн ажгуу.

8 Мөн эдүгээ үхэлтэй учирсан түүний дүү (түүний нэр Нимра байв) эцгийнх нь ахад нь хийсэн тэр зүйлийн улмаас эцэгтээ хилэgnэж байв.

9 Мөнхүү улиран тохиох дор Нимра цөөн тооны эрчүүдийг цуглуулан, мөн уг нутгаас дайжив, мөн ирж тэгээд Омертой хамт суурьшив.

10 Мөнхүү улиран тохиох дор Акиш өөр бусад хөвгүүдийг төрүүлэв, мөн хэдийгээр тэд хүссэний дагуу бүх л төрлийн алдсыг хийхээр түүнд андгайлсан тэр хүмүүсийн зүрх сэтгэлийг татжээ.

11 Эдүгээ Акиш хүч чадлыг олохыг хүсдэг байсан лугаа адил, Акишийн хүмүүс хөрөнгө олохыг хүсдэг байв; иймийн тул, Акишийн хөвгүүд тэдэнд мөнгө өгөхөөр болов, үүгээрээ тэд хүмүү-

сийн ихээхэн хэсгийг араасаа дагуулав.

12 Мөн Акишийн хөвгүүд болон Акишийн хооронд, тийм ээ, хаант улсын бараг бүх хүмүүсийн тийм ээ, гучин бодгиалиас, мөн Омержын угсаатай хамт дүрвэсэн тэднээс бусад бүгдийг устгалд хүргэсэн олон жилийн туршид үргэлжилсэн дайн эхлэв.

13 Иймийн тул, Омер өвийн нутагтаа дахин сэргээгдэв.

14 Мөнхүү улиран тохиох дор Омер нас өндөр болж эхлэв; гэсэн хэдий ч, өндөр насандаа тэрээр Имерийг төрүүлэв; мөн тэрээр Имерийг өөрийн оронд засаглах хаан байхаар тослов.

15 Мөн тэрээр Имерийг хаан болгохоор авшиг хүртээснийхээ дараа, тэрээр хоёр жилийн туршид уг нутагт амар амгаланг тэрээр үзэв, мөн гашуудлаар дүүрэн байсан үлэмж олон өдрийг үзжээ мөн тэрээр нас нөгчив. Мөнхүү улиран тохиох дор Имер түүний оронд засаглаж, мөн эцгийнхээ мөрөөр замнасан букуу.

16 Мөн Их Эзэн уг нутгаас зүхлийг дахин холдуулж эхлэв, мөн Имерийн үр удам Имэрийн засаглалын дор үлэмж дэгжив; мөн жаран хоёр жилийн дотор тэд үлэмж хүчирхэг болж, үүний хэрээр тэд үлэмж баян болцгоов—

17 Бүх л төрлийн жимс, мөн

үр тариа, мөн торго, мөн нарийн нэхээст эд, мөн алт, мөн мөнгө, мөн үнэт зүйлстэй байв;

18 Мөн түүнчлэн бүх төрлийн мал, шар, мөн үнээ, мөн хонь, мөн гахай, мөн ямаа, мөн түүнчлэн хүмүүний оол хүнсэнд тустай бусад олон төрлийн амьтадтай байв.

19 Мөн тэд түүнчлэн “морь, мөн илжигтэй байв, мөн заан мөн кюрулом мөн күмомуудтай байв; энэ бүгд нь, мөн ялангуяа заан мөн кюрулом мөн күмом нь хүмүүнд тустай байсан бөлгөө.

20 Мөн тийн Их Эзэн бусад бүх нутгаас дээгүүр “сонгомол асан энэ нутагт адислалуудаа цутгав; мөн уг нутгийг эзэмших хэн боловч үүнийг Их Эзэний төлөө эзэмшихийг тэрээр зарлиг болсон ажээ, эс бөгөөс алдасгаа бүрнээ боловсорсон үед тэд “устгагдах болно; учир нь ингэх тэдний дээр: Би уур хилэнгээ бүрнээр нь цутгах болно хэмээн Их Эзэн хэлсэн ажээ.

21 Мөн Имер өөрийн бүх өдөртөө, зөв шударгаар хууль цаазыг хэрэгжүүлж, мөн тэрээр олон хөвгүүд мөн охидыг төрүүлэв; мөн тэрээр Кориантумыг төрүүлж, мөн Кориантумыг өөрийн оронд засаглуулахаар тослов.

22 Мөн тэрээр өөрийн оронд засаглуулахаар Кориантумыг тосолсны дараа тэрээр дөрвөн жил амьдарсан ажгуу, мөн

тэрээр уг нутагт амар амгаланг үзэв; тийм ээ, мөн тэрээр бүр Зөв Шударгын “Хүүг харав, мөн түүний өдөрт баясаж мөн бахархав; мөн тэрээр амар амгаланд нас нөгчив.

23 Мөнхүү улиран тохиох дор Кориантум эцгийнхээ мөрөөр замнаж, мөн олон хүчирхэг хот барьж, мөн өөрийн бүх өдрүүддээ өөрийн хүмүүст сайн болох түүнийг гүйцэтгэсэн буюу. Мөнхүү улиран тохиох дор тэрээр бүр нас үлэмж өндөр болох хүртлээ үр хүүхэдгүй байжээ.

24 Мөнхүү улиран тохиох дор түүний эхнэр, зуун хоёр насыг зооглон, өөд болов. Мөнхүү улиран тохиох дор Кориантум өндөр насандаа, залуу бүсгүйг эхнэр болгон авч, мөн хөвгүүд болоод охидыг төрүүлэв; иймийн тул тэрээр зуун дөчин хоёр нас хүртлээ амьдарсан бөлгөө.

25 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Комыг төрүүлж, мөн Ком түүний оронд засаглав; мөн тэрээр дөчин есөн жил засаглаж, мөн тэр Хэтийг төрүүлэв; мөн тэр түүнчлэн бусад хөвгүүд хийгээд охидыг төрүүлэв.

26 Мөнхүү хүмүүс дахин нутгийн бүх гадаргуу дээр тархсан байв, мөн уг нутгийн гадаргуу дээр дахин үлэмж агуу ёс бусын үйл бий болж эхлэв, мөн Хет өөрийн эцгийг устгахаар эртний нууц төлөвлөгөөнүүдийг дахин өөгшүүлэн дэмжиж эхлэв.

27 Мөнхүү улиран тохиох дор тэрээр эцгээ хаан ширээнээс нь унагав, учир нь тэрбээр түүнийг өөрийнх нь илдээр хөнөөсөн ажгуу; мөн тэрээр түүний оронд засаглав.

28 Мөн бошиглогчид, тэдэнд наманчлалыг тунхагласаар уг хутагт дахин ирэв—тэд Их Эзэний замыг бэлтгэх ёстой эсвээс уг нутгийн гадаргуу дээр зүхэл ирэх болно; тийм ээ, хэрэв тэд эс наманчлах аваас бүр агуу өлсгөлөн болж тэд түүгээр устгагдах болно гэв.

29 Гэвч хүмүүс бошиглогчдын үгэнд итгэсэнгүй, харин тэд тэднийг хөөн зайлуулав; мөн тэдний заримыг нь нүхэнд хаян мөн тэднийг эрсдүүлэхээр орхив. Мөнхүү улиран тохиох дор тэд эдгээр бүх зүйлийг хаан Хетийн зарлигийн дагуу үйлджээ.

30 Мөнхүү улиран тохиох дор уг нутагт агуу өлөн зэлмүүн байж эхлэв, мөн газрын гадаргуу дээр хур бороо эс орсны учир, оршин суугчид нь өлөн зэлмүүнээс болон үтэр түргэнээр устгагдаж эхлэв.

31 Мөн нутгийн гадаргуу дээр түүнчлэн хорт могойнууд гарч ирж, мөн олон хүмүүнийг хордуулсан аж. Мөнхүү улиран тохиох дор тэдний мал хорт могойнуудын өмнө, нифайчуудаар “Зарахемла хэмээн нэрлэгдсэн өмнөд нутаг тийш дайжиж эхлэв.

32 Мөнхүү улиран тохиох дор

тэдний олон нь замдаа эрсэдсэн ажээ; гэсэн хэдий ч, өмнө зүгийн нутагт дайжиж хүрсэн зарим нь байв.

33 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн “могойнууд тэднийг цааш үлдэн хөөхгүй болгон, харин өнгөрч гарах гэсэн хэн бүхэн хорт могойнуудад хөнөөгдөн унаж болохын тулд хүмүүс өнгөрөн гарч чадахааргүйгээр могойнуудаар замыг нь хаах болгосон ажээ.

34 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс амьтдын жимийг даган, мөн замаар унасан тэдний сэгийг, тэд бүгдийг нь идэж дуусгах хүртэл, ховдоглон идэв. Эдүгээ хүмүүс эрсдэх учиртайгаа үзээд тэд алдсаа “наманчилж мөн Их Эзэнд залбиран гуйж эхлэв.

35 Мөнхүү улиран тохиох дор тэд Их Эзэний өмнө өөрсдийгөө хангалттайгаар “даруусгасны нь дараа тэр газрын гадаргуу дээр хур илгээв; мөн хүмүүс дахин тэнхэрч эхлэн, мөн умард зүгийн нутгуудад, мөн бүх эргэн тойрны нутгуудад жимс байж эхлэв. Мөнхүү Их Эзэн тэднийг өлсгөлөнгөөс хамгаалснаар тэдэнд хүчээ үзүүлсэн буюу.

БҮЛЭГ 10

Нэг хаан нөгөөгөө залгамжилна—Хаадын зарим нь зөв шударга; бусад зарим нь ёс бус—Зөв шударга ёс давамгайлахад,

хүмүүс Их Эзэнээр адислагдаж мөн цэцэглэн хөгждөг.

Мөнхүү улиран тохиох дор Хетийн удам асан, Шез—Хет, мөн Шезээс бусад түүний бүх гэрийнхэн, өлсгөлөнгөөр үрэгдсэн учир—иймийн тул, Шез бутарсан хүмүүсээ дахин нэгтгэж эхлэв.

2 Мөнхүү улиран тохиох дор Шез эцэг өвгөдийнхөө устгалыг санаж байв, мөн тэрээр зөв шударга хаант улсыг байгуулав; учир нь Их Эзэн Жаред мөн түүний ахыг гүнийг “гатлуулан авчрахад юу хийснийг тэрбээр санаж байв; мөн тэрбээр Их Эзэний замаар алхаж байлаа; мөн тэр хөвгүүд болон охидыг төрүүлсэн бөлгөө.

3 Мөн түүний, Шез хэмээх нэртэй асан, ууган хүү нь түүний эсрэг босов; гэсэн хэдий ч, Шез, үлэмж баялгийнхаа улмаас, дээрэмчний гараар бут цохигдсоноос, ийн эцэгт нь ахин амар амгалан авчрагдав.

4 Мөнхүү улиран тохиох дор түүний эцэг нутгийн гадаргуу дээр олон хот босгож, мөн хүмүүс дахин нутгийн бүх гадаргуу дээгүүр тархаж эхлэв. Мөн Шез үлэмж өндөр нас хүрч амьдрал; мөн тэрээр Рипликишийг төрүүлэв. Мөн тэрээр нас нөгчиж, тэгээд Рипликиш түүний оронд засаглав.

5 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний мэлмийд зөв

болох түүнийг Рипликиш эс үйлдэв, учир нь тэр олон эхнэр мөн “татвар эмстэй байв, мөн үүрэхэд хүнд байсан түүнийг хүмүүсийн мөрөн дээр тавьсан ажээ; тийм ээ, тэрбээр тэднээс хүнд татвар татаж байв; мөн татвараар тэрээр олон сэлүүхэн барилгуудыг барьжээ.

6 Мөн тэрээр үлэмж үзэсгэлэнт хаан ширээг өөртөө босгов, мөн тэрээр олон шорон барьж, мөн татварт үл харъяалагдах гэсэн хэн бүхнийг тэрээр шоронд хаяж байлаа; мөн татвараа төлөх чадваргүй хэн бүхнийг тэрээр шоронд тэд өөрсдийгөө тэтгэхийн тулд үргэлж хөдөлмөрлөх болгосон аж; мөн хөдөлмөрлөхөөс татгалзсан хэн бүхнийг тэрээр үхэлд хүргэгдэхээр болгосон ажгуу.

7 Иймийн тул тэрээр өөрийн бүх сайн бүтээлийг олж авсан аж, тийм ээ, өөрийн шижир алтыг тэрээр шоронд цэвэршүүлэх болгов; мөн бүх л төрлийн уран сайн хийцүүдийг тэрээр шоронд бүтээлгэ гэдэг байв. Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүмүүсийг өөрийн садар самуун мөн жигшүүрт хэргүүдээрээ зовоож шаналгасан аж.

8 Мөн тэрээр дөчин хоёр жилийн туршид засаглахад хүмүүс түүний эсрэг бослого гаргав; мөн нутагт дахин дайн эхлэв, үүний хэрээр Рипликиш алагдаж, мөн

түүний үр удам уг нутгаас хөөгджээ.

9 Мөнхүү улиран тохиох дор олон жилийн дараа, Мориантон, (тэрээр Рипликишийн удам байв) гадуурхагдагсдаас их цэргийг цуглуулан бүрдүүлж, мөн давшин явж мөн хүмүүстэй тулалдаанд оров; мөн тэрээр олон хотын дээр хүчийг олсон болой; мөн дайн үлэмж ноцтой болж, мөн олон жилийн туршид үргэлжлэв; мөн тэрээр бүх нутгийн дээр хүчийг олж, мөн бүх нутгийн дээр өөрийгөө хаанаар өргөмжлөв.

10 Мөн өөрийгөө тэрээр хаанаар өргөмжилсний дараа тэрбээр хүмүүсийн ачаа үүргийг хөнгөлж, тэгснээрээ хүмүүсийн нүдэнд тааллыг олжээ, мөн тэд түүнийг хаанаа байхаар тослон адислав.

11 Мөн тэрээр хүмүүст шударгаар үйлдэж байв, гэвч өөрийн олон садар самууны улмаас өөртөө эс бөлгөө; иймийн тул тэрээр Их Эзэний дэргэдээс тусгаарлагдсан ажгуу.

12 Мөнхүү улиран тохиох дор Мориантон олон хот босгож, мөн хүмүүс түүний засаглалын дор барилгаар, мөн алт болон мөнгөөр, мөн үр тариа ургуулснаар, мөн бог болон бод мал, мөн тэдэнд сэргээгдсэн тийм зүйлүүдээр үлэмж баян болов.

13 Мөн Мориантон үлэмж агуу насыг зооглон амьдарч, тэгээд тэр Кимийг төрүүлэв;

мөн Ким эцгийнхээ оронд засаглав; мөн тэрээр найман жил засаглаж, мөн эцэг нь нас нөгчив. Мөнхүү улиран тохиох дор Ким зөв шударгад эс засаглаж, иймийн тул тэрээр Их Эзэний ээл хишгийг үл хүртсэн ажгуу.

14 Мөн түүний дүү нь түүний эсрэг бослого гаргаж, тэгснээрээ түүнийг боолчлолд авчрав; мөн тэрээр амьдралынхаа бүх өдрүүдэд боолчлолд үлдсэн болой; мөн тэрээр боолчлолд хөвгүүд мөн охидыг төрүүлж, мөн өндөр насандаа тэрээр Ливайг төрүүлэв; мөн тэрээр нас нөгчив.

15 Мөнхүү улиран тохиох дор, Ливай эцгээ нас нөгчсөнөөс хойш дөчин хоёр жилийн турш боолчлолд үйлчлэв. Мөн тэрээр уг нутгийн хааны эсрэг дайн хийж, тэгснээр тэрээр хаант улсыг өөртөө авав.

16 Мөн хаант улсыг тэрээр өөртөө авсны дараа тэрээр Их Эзэний мэлмийд зөв болох түүнийг үйлдэв; мөн хүмүүс нутагт дэгжив; мөн тэрээр их өндөр нас зооглон амьдарч, мөн хөвгүүд хийгээд охидыг төрүүлэв; мөн тэрээр Коромыг төрүүлж, түүнийг тэрээр өөрийн оронд хаан болгон тослон адисалжээ.

17 Мөнхүү улиран тохиох дор Кором өөрийн бүх өдрүүдэд Их Эзэний мэлмийд сайн болох түүнийг үйлдэв; мөн тэрээр олон хөвгүүд

болоод охидыг төрүүлжээ; мөн тэрээр олон өдрийг үзсэний дараа, дэлхийн бусадтай адилаар тэрээр нас нөгчив; мөн Киш түүний оронд засаглав.

18 Мөнхүү улиран тохиох дор Киш түүнчлэн нас нөгчиж, мөн Либ түүний оронд засаглав.

19 Мөнхүү улиран тохиох дор Либ түүнчлэн Их Эзэний мэлмийд сайн болох түүнийг үйлдэв. Мөн Либийн өдрүүдэд “хорт могойнууд устгагдав. Иймийн тул тэд өмнө зүгийн нутаг тийш, уг нутгийн хүмүүст хүнс болгохоор ан хийхийн тулд явцгаав, учир нь уг нутаг ойн амьтдаар бүрхэгдсэн байв. Мөн Либ түүнчлэн өөрөө агуу анчин болов.

20 Мөн тэд нутгийн нарийн хоолойвчид, нутгийг тэнгис хувааж буй хэсэг газрын дэргэд нэгэн агуу хот байгуулав.

21 Мөн тэд өмнө зүгийн нутгийг, ан авын тулд, аглаг буйд хэвээр нь хадгалав. Мөн хойд зүгийн бүх нутгийн гадаргуу оршин суугчдаар дүүрэв.

22 Мөн тэд үлэмж хөдөлмөрч байв, мөн тэд худалдан авч мөн худалдаж мөн тэд олз олж болохын тулд, нэг нэгэнтэйгээ арилжаа хийж байв.

23 Мөн тэд бүх л төрлийн хүдэртэй ажиллаж, мөн тэд алт, мөн мөнгө, мөн “төмөр, мөн гууль, мөн бүх л төрлийн төмөрлөгүүдийг гаргаж байв;

мөн тэд түүнийг газраас олборлож байв; иймийн тул, тэд алтны, мөн мөнгөний, мөн төмрийн, мөн зэсийн хүдэр гаргаж авахын тулд ихээхэн газрын хөрсийг овоолсон байлаа. Мөн тэд бүх төрлийн сайн бүтээлүүдийг үйлдэв.

24 Мөн тэд торго, мөн нарийн нэхээст бөс даавуутай байв; мөн тэд өөрсдийн нүцгэнийг халхлахаар, бүх төрлийн бөс даавуу хийж байв.

25 Мөн тэд газар боловсруулах, хагалах мөн тарих, хадах мөн зээтүүдэх, мөн түүнчлэн цайруулах бүх төрлийн багажнууд хийв.

26 Мөн тэд амьтдаа ажиллуулах бүх төрлийн багажууд хийв.

27 Мөн тэд дайны бүх төрлийн зэвсгүүд хийв. Мөн тэд бүх л төрлийн үлэмж уран чамин хийцтэй бүтээлүүд үйлдэв.

28 Мөн Их Эзэний мутраар тэднээс илүү адислагдсан, мөн илүү хөгжүүлэгдсэн хүмүүс хэзээ ч байх аргагүй юм. Мөн тэд бүх нутгаас дээгүүр сонгомол нутагт байлаа, учир нь Их Эзэн үүнийг хэлсэн бөлгөө.

29 Мөнхүү улиран тохиох дор Либ олон жил амьдарч, мөн хөвгүүд болоод охидыг; мөн тэрээр түүнчлэн Харфомыг төрүүлэв.

30 Мөнхүү улиран тохиох дор Харфом эцгийнхээ оронд засаглав. Мөн Харфом хорин дөрвөн жил засагласан үед,

болгоогтун, хаант улс түүнээс булаагдан авагдав. Мөн тэрээр олон жилийг, тийм ээ, бүр өөрийн өдрүүдийн бүх үлдсэнийг боолчлолд үйлчлэв.

31 Мөн тэрээр Хетийг төрүүлж, мөн Хет өөрийн бүх өдрүүдэд боолчлолд амьдарсан буюу. Мөн Хет Аароныг төрүүлж, мөн Аарон өөрийн бүх өдрүүдэд боолчлолд оршив; мөн тэрээр Амнигаддаг төрүүлж, мөн Амнигадда түүнчлэн өөрийн бүх өдрүүдэд боолчлолд оршив; мөн тэрээр Кориантумыг төрүүлж, мөн Кориантум өөрийн бүх өдрүүдэд боолчлолд оршив; мөн тэрээр Комыг төрүүлэв.

32 Мөнхүү улиран тохиох дор Ком хаант улсын хагасыг дагуулан одов. Мөн тэрээр хаант улсын хагасын дээр дөчин хоёр жил засаглав; мөн тэрээр хаан Амгидын эсрэг тулалдаанд орж, мөн тэд олон жилийн туршид тулалдан, энэ цагийн хооронд Ком Амгидын дээр хүчийг олж, мөн хаант улсын үлдсэн хэсгийн дээр хүчийг олж авсан бөлгөө.

33 Мөн Комын өдрүүдэд уг нутагт дээрэмчид байж эхлэв; мөн тэд хуучин төлөвлөгөөнүүдийг авч хэрэглэн, мөн эртнийхний адилаар “тангараг үйлдэх болов, мөн хаант улсыг устгахаар дахин эрэлхийлэв.

34 Эдүгээ Ком тэдний эсрэг маш их тулалдаж байв; гэсэн

хэдий ч, тэр тэднийг дийлсэн нь үгүй.

БҮЛЭГ 11

Дайнууд, тэрслэлүүд, мөн ёс бус үйл жаредчуудын амьдралд ноёлов — Тэд эс наманчлах аваас жаредчуудын бүрмөсөн устгалыг бошиглогчид зөгнөв — Хүмүүс бошиглогчдын үгсийг эсэргүүцэв.

Мөн түүнчлэн Комын өдрүүдэд олон бошиглогч ирж, мөн тэр агуу хүмүүс наманчилж, мөн Их Эзэнд хандан, мөн өөрсдийн аллага хийгээд ёс бусын үйлээ орхих ёстойг, эс бөгөөс тэдний устгалын тухай бошиглов.

2 Мөнхүү улиран тохиох дор бошиглогчид хүмүүсээр эсэргүүцэгдэв, мөн хүмүүс тэднийг устгахаар эрэлхийлсний учир, тэд хамгаалахыг хүсэн Комд зугтаж очив.

3 Мөн тэд Комд олон зүйлийг бошиглов; мөн тэрээр өөрийн өдрүүдийн үлдсэн хугацаанд адислагдав.

4 Мөн тэрээр их өндөр насыг хүртэл амьдарч, мөн Шибломыг төрүүлэв; мөн Шиблом түүний оронд засаглав. Мөн Шибломын дүү түүний эсрэг босож, мөн бүх л нутагт үлэмж агуу дайн эхлэв.

5 Мөнхүү улиран тохиох дор Шибломын дүү хүмүүсийн устгалын талаар бошиглохон бүх бошиглогчдыг үхэлд хүргэгдэх болгов;

6 Мөн бүх нутагт агуу гай гамшиг тохиов, учир нь тэд өөрсдийн ёс бус үйлээсээ наманчлахгүй аваас агуу зүхэл уг нутагт, мөн түүнчлэн хүмүүсийн дээр ирэх болно, мөн тэдний дунд, газрын гадаргуу дээр хэзээ ч байгаагүй тийм агуу устгал байх болно, мөн тэдний яс нутгийн гадаргуу дээр газрын “овоологдсон хөрс лугаа адил болно хэмээн тэд гэрчилж байв.

7 Мөн тэд өөрсдийн ёс бус хуйвалдаануудын улмаас Их Эзэний дуу хоолойг сонссон нь үгүй; иймийн тул, бүх нутагт дайн мөн зөрчилдөөн байв, мөн түүнчлэн олон өлсгөлөн мөн тахал байж эхлэв, үүний хэрээр, газрын гадаргуу дээр хэзээ ч байгаагүй тийм агуу устгал болов; мөнхүү энэ бүхэн Шибломын өдрүүдэд улиран тохиосон ажгуу.

8 Мөн хүмүүс алдсаа наманчилж эхлэв; мөн тэгсний хэрээр Их Эзэн тэдэнд “нигүүлсэл үзүүлэв.

9 Мөнхүү улиран тохиох дор Шиблом хөнөөгдөв, мөн Сет боолчлолд авчрагдаж, мөн өөрийн бүх өдрүүдэд боолчлолд оршсон буюу.

10 Мөнхүү улиран тохиох дор түүний хүү Аха хаант улсыг авав; мөн тэрээр өөрийн бүх өдрүүдэд хүмүүсийн дээр засагласан бөлгөө. Мөн тэрээр өөрийн өдрүүдэд бүх төрлийн алдсыг хийсэн боллойд, тэгснээр тэр маш их цус

урсах болгов; мөн цөөхөн байсан болой түүний өдрүүд.

11 Мөн Ифем, Ахагийн удам байсан тул, хаант улсыг авав; мөн тэрээр өөрийн өдрүүдэд түүнчлэн ёс бус болох түүнийг үйлдсэн бөлгөө.

12 Мөнхүү улиран тохиох дор Ифемийн өдрүүдэд олон бошиглогчид ирж, мөн хүмүүст дахин бошиглов; тийм ээ, тэд алдсуудаа наманчлахгүй аваас Их Эзэн тэднийг газрын гадаргуу дээрээс бүрмөсөн устгах болно хэмээн тэд бошиглосон ажээ.

13 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс зүрх сэтгэлээ хатууруулж, мөн тэдний үгийг “анхааран сонсохгүй байв; мөн бошиглогчид гашуудаж мөн хүмүүсийн дундаас холдон явав.

14 Мөнхүү улиран тохиох дор Ифем өөрийн бүх өдрүүдэд хууль цаазыг ёс бусаар хэрэгжүүлж байв; мөн тэрээр Мороныг төрүүлэв. Мөнхүү улиран тохиох дор Морон түүний оронд засаглав; мөн Морон Их Эзэний өмнө ёс бус болох түүнийг үйлдсэн буюу.

15 Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн дунд, хүч хийгээд эд хөрөнгийг олохоор бий болсон нууц хуйвалдааны улмаас “бослого гарав; мөн тэдний дунд алдастаа хүчирхэг нэгэн эр босож мөн Моронтой тулаанд оров, тэгснээр тэрбээр хаант улсын хагасыг унагав; мөн тэрээр

хаант улсын хагасыг олон жилд барьсан болой.

16 Мөнхүү улиран тохиох дор Морон түүнийг унагаж, мөн хаант улсыг дахин авав.

17 Мөнхүү улиран тохиох дор бас нэгэн хүчит эр гарч ирэв; мөн тэрбээр Жаредын ахын удам байв.

18 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Мороныг унагааж мөн хаант улсыг авав; иймийн тул, Морон өөрийн үлдсэн бүх өдрүүдэд боолчлолд оршив; мөн тэрээр Корианторыг төрүүлэв.

19 Мөнхүү улиран тохиох дор Кориантор өөрийн бүх өдрүүдэд боолчлолд оршсон авай.

20 Мөн Корианторын өдрүүдэд түүнчлэн олон бошиглогчид иржээ, мөн агуу хийгээд гайхамшигт зүйлийг бошиглож, мөн тэд наманчлахгүй аваас Их Эзэн Бурхан тэднийг бүрмөсөн устгалд хүргэх “хууль цаазыг тэдний эсрэг хэрэгжүүлэх болно хэмээн хүмүүст наманчлалыг тунхаглав;

21 Мөн Их Эзэн Бурхан өөрийн хүчээр, уг нутгийг эзэмшүүлэхээр, тэрээр тэдний эцэг дээдсийг авчирсан тэр байдлаар, “бусад хүмүүсийг илгээх болно, өөрөөр хэлбэл авчрах болно гэв.

22 Мөн өөрсдийн нууц нийгэмлэг хийгээд ёс бус жигшүүрт үйлүүдийн улмаас тэд бошиглогчдын бүх үгсийг эсэргүүцсэн болой.

23 Мөнхүү улиран тохиох дор

Кориантор “Иферийг төрүүлэв, мөн тэрээр, өөрийн бүх өдрүүдэд боолчлолд оршсоор нас нөгчив.

БҮЛЭГ 12

Бурханд итгэхийг Бошиглогч Ифер хүмүүст ухуулав—Итгэлээр хийгдсэн гайхамигууд хийгээд ер бусын үйлүүдийг Моронай дахин тоочив—Итгэл нь Жаредын ах Христийг харах боломжтой болгов—Тэд даруу байж болохын тулд хүмүүст сул дорой байдлыг Их Эзэн өгдөг—Жаредын ах Зериний Уулыг итгэлээр нүүлгэв—Авралын тулд итгэл, найдвар, мөн энэрэл шаардлагатай—Моронай Есүсийг нүүр тулан харав.

Мөнхүү улиран тохиох дор Иферийн өдрүүд Кориантумын өдрүүдэд байв; мөн “Кориантумр бүх нутгийн дээр хаан байлаа.

2 Мөн “Ифер Их Эзэний бошиглогч байв; иймийн тул Ифер Кориантумын өдрүүдэд ирж, мөн хүмүүст бошиглож эхлэв, учир нь түүнд орших Их Эзэний Сүнсний улмаас тэрээр ^бзогсоогдож чадахгүй байв.

3 Тэрээр өглөөнөөс эхлэн бүр нар жаргах хүртэл, хүмүүсийг наманчлалд хүргэх Бурханд итгэхийг, эс бөгөөс тэд “устгагдах болуузай

хэмээн ухуулан, ^битгэлээр бүх зүйлс гүйцэлддэгийг тэдэнд ^ххэлэн тунхаглав—

4 Иймийн тул, Бурханд итгэдэг хэн боловч, илүү сайн дэлхийд, тийм ээ, Бурханы баруун гар талд байх нэгэн байрны төлөө лавтайяа “найдаж болох, уг найдвар нь итгэлээр ирж, хүмүүсийн бодгальд ^бзангуу болдог, тэр нь тэднийг тууштай мөн хөдөлшгүй “сайн үйлээр үргэлж дүүрэн, бас Бурханыг ‘алдаршуулахад удирдагдах болгодог.

5 Мөнхүү улиран тохиох дор Ифер агуу хийгээд гайхамшигт зүйлийг хүмүүст бошиггосон аж, тэд тэдгээрийг эс үзсэний учир, тэд тэдгээрт нь итгэсэнгүй.

6 Мөн эдүгээ, би, Моронай, эдгээр зүйлийн талаар заримыг ярья; “итгэл бол ^бнайдагдсан боловч “үзэгдээгүй зүйлүүд гэдгийг би дэлхийд үзүүлнэ; иймийн тул, та нар хараагүйн улмаас бүү арсалд, учир нь итгэлийн тань ‘сорилтын дарааг хүртэл та нар гэрчийг хүлээн авахгүй.

7 Учир нь Христ бидний өвөг дээдэст, тэрээр үхлээс боссоныхоо дараа, өөрийгөө үзүүлсэн нь итгэлээр байсан буюу; мөн тэднийг өөрт нь итгэлтэй болсны дарааг хүртэл тэрээр өөрийгөө тэдэнд үзүүлээгүй юм; иймийн тул,

23а Ифер 1:6; 15:33–34.

12 1а Ифер 13:13–31.

2а су Ифер.

б Иер. 20:9; Инос 1:26;

Алма 43:1.

3а Ифер 11:12, 20–22.

б су Итгэл.

в С ба Г 112:5.

4а су Найдвар.

б Евр. 6:19.

в 1 Кор. 15:58.

г 3 Ниф. 12:16.

6а Евр. 11:1.

б Ром 8:24–25.

в Алма 32:21.

г 3 Ниф. 26:11;

С ба Г 105:19; 121:7–8.

түүнд зарим нь итгэлтэй байсан гэдэг нь зайлшгүй, учир нь тэрээр өөрийгөө дэлхийд үзүүлээгүй.

8 Гэвч хүмүүсийн итгэлийн улмаас тэрээр өөрийгөө дэлхийд үзүүлж, мөн Эцэгийн нэрийг алдаршуулан, мөн бусад зарим нь тэнгэрлэг бэлгээс хүртэгсэд байж болохын тулд, тэд үзээгүй зүйлүүддээ найдаж болохын тулд замыг бэлтгэсэн бөлгөө.

9 Иймийн тул, та нар ч түүнчлэн, хэрэв та нар итгэлтэй л байх аваас, найдварыг агуулж, мөн уг бэлгээс хүртэгсэд байж болно.

10 Болгоогтун эртний тэд Бурханы ариун жаягаар “дуудагдсан нь итгэлээр байсан буюу.

11 Иймийн тул, Мосегийн хууль өгөгдсөн нь итгэлээр байсан юм. Гэвч өөрийн Хүүгийн бэлгээр Бурхан илүүтэй “онцгой замыг бэлтгэсэн бөлгөө; мөн үүний гүйцэлдсэн нь итгэлээр юм.

12 Учир нь хэрэв хүмүүний үрсийн дунд “итгэл үгүй бол Бурхан тэдний дунд ямар ч гайхамшгийг үйлдэж эс чадах буюу; иймийн тул, тэдний итгэлийн дарааг хүртэл тэрээр өөрийгөө үзүүлээгүй.

13 Болгоогтун, “шоронг га-

зарт нуран унах болгосон нь Алма Амюлек хоёрын итгэл байсан юм.

14 Болгоогтун, тэд галаар мөн “Ариун Сүнсээр баптисм хүртэхэд хүргэх өөрчлөлтийг леменчүүдийн дээр авчирсан нь Нифай Лихай хоёрын итгэл байсан юм.

15 Болгоогтун, леменчүүдийн дунд нэтэд агуу гайхамшгийг “үйлдсэн нь Аммон мөн түүний ахан дүүсийн итгэл байсан юм.

16 Тийм ээ, мөн “гайхамшгийг үйлдсэн бүр тэд бүгд нь, бүр Христийн өмнө мөн басхүү дараа нь байсан тэд, тэдгээрийг итгэлээр үйлдсэн юм.

17 Мөн уг гурван шавь үхлийг “эс амсана хэмээх амлалтыг олж авсан нь итгэлээр байсан юм; мөн тэд итгэлийнхээ дарааг хүртэл амлалтыг олж авсан нь үгүй.

18 Мөн итгэлийнхээ дарааг хүртэл хэн ч хэзээ ч гайхамшгийг үйлдсэн нь үгүй; иймийн тул тэд эхлээд Бурханы Хүүд итгэсэн бөлгөө.

19 Мөн “гивлүүрийн гадна хадгалагдаж чадахааргүй тэд, харин итгэлийн нүдээр болгосон тэр зүйлийг өөрсдийн нүдээр үнэхээр хараад мөн баяртай байлаа, итгэл нь

10a Алма 13:3–4.

су Дуудах,
Бурханаас
дуудагдах,
Дуудлага.

11a 1 Кор. 12:31.

12a 2 Ниф. 27:23;

Мозая 8:18;
Моро. 7:37;

С ба Г 35:8–11.

б Мат. 13:58;

Морм. 9:20.

13a Алма 14:26–29.

14a Хил. 5:45;

3 Ниф. 9:20.

б Хил. 5:50–52.

15a ө.х. Алма бүлэг

17-26-д өгүүлсэн

болно.

б Алма 17:29–39.

16a су Гайхамшиг.

б Евр. 11:7–40.

17a 3 Ниф. 28:7;

Морм. 8:10–12.

19a Ифер 3:6.

су Хөшиг.

тийм үлэмж хүчирхэг байсан тэд бүр Христийг ирэхээс ^бөмнө ч олон байв.

20 Мөн болгоогтун, эдгээрийн нэг нь Жаредын ах байсныг бид энэхүү цэдэгт үзсэн бөлгөө; учир нь түүний итгэлээрээ олж авсан үг болох, Бурхан өөрөө түүнд хэлсэн үгийн учир, тэр “хуруугаа сунгахад, Жаредын ахын харцнаас нууж эс чадахаар Бурханд итгэх түүний итгэл тийм агуу байв.

21 Мөн Жаредын ахын итгэлээр олж авсан “амлалтын улмаас, Жаредын ах Их Эзэний хурууг болгоосны дараа, Их Эзэн түүний харцнаас юуг ч зайлуулж эс чадсан бөлгөө; иймийн тул тэрээр түүнд бүх зүйлийг үзүүлсэн аж, учир нь тэрээр ^бгивлүүрийн гадна цаашид хадгалагдаж эс чадсан буюу.

22 Мөн миний эцэг дээдэс эдгээр зүйлийг тэдний ахан дүүст харийнханаар дамжуулан ирүүлнэ гэсэн “амлалт олж авсан нь итгэлээр байсан юм; тиймийн тул Их Эзэн, тийм ээ, бүр Есүс Христ надад зарлигласан бөлгөө.

23 Мөн би түүнд хэлэв: Их Эзэн, бидний бичгийн “сул дорой байдлын улмаас, харийнхан эдгээр зүйлийг шоолох болно; учир нь Их Эзэн та биднийг ярихдаа хүчтэй болгосон, гэвч та биднийг

бичихдээ ^бхүчит болгосон нь үгүй; учир нь та өөрийн тэдэнд өгсөн Ариун Сүнсний улмаас, энэ бүх хүмүүсийг, тэд ихийг ярьж чадахаар болгосон билээ;

24 Мөн бидний гар болхийн улмаас, та биднийг багыг л бичиж чаддаг болгосон буюу. Болгоогтун, та биднийг Жаредын ахын адил “бичихдээ хүчтэй болгосон нь үгүй, учир нь түүний бичсэн зүйлүүд, тэдгээрийг унших болгон хүмүүнийг эзэмдэхүйц таны адил тийм хүчтэй байхаар түүнийг хүчирхэг болгосон бөлгөө.

25 Бид бүр бичиж чадахааргүйгээр, та бидний үгсийг хүчирхэг мөн агуу болгосон; иймийн тул, бичихдээ бид өөрсдийн сул доройг болгоож, мөн өөрсдийн үгийг байрлуулахын улмаас бүдэчдэг; мөн харийнхан бидний үгсийг “шоолох буйза хэмээн би эмээнэ.

26 Мөн би үүнийг хэлэхэд, Их Эзэн надад ярьж, хэлрүүн: Тэнэгүүд “шоолдог, гэвч тэд гашуудах болно; мөн тэд та нарын сул доройг үл ашиглахын тулд, номхон дөлгөөн тэдэнд миний ач ивээл хангалттай;

27 Мөн хэрэв хүмүүс надад ирэх аваас би тэдэнд өөрсдийнх нь “сул доройг үзүүлэх болно. Тэд даруу байж боло-

19б 2 Ниф. 11:1–4;
Иаков 4:4–5;
Жером 1:11;
Алма 25:15–16.
20а Ифер 3:4.

21а Ифер 3:25–26.
б Ифер 3:20;
С ба Г 67:10–13.
22а Инос 1:13.
23а Морм. 8:17; 9:33.

б 2 Ниф. 33:1.
24а су Хэл.
25а 1 Кор. 2:14.
26а Гал. 6:7.
27а Иаков 4:7.

хын тулд би хүмүүст сул доройг өгдөг; мөн миний өмнө өөрсдийгөө даруусгадаг бүх хүмүүст миний ⁶ач ивээл хангалттай; учир нь хэрэв тэд миний өмнө өөрсдийгөө ⁶даруусгаж, мөн надад итгэлтэй байх аваас, тэгвэл би тэдэнд ⁷сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож ⁸өгнө.

28 Болгоогтун, харийнханд би сул доройг нь үзүүлэх болно, мөн “итгэл, найдвар хийгээд энэрэл нь надад авчирдгийг — бүх зөв шударгын эх булагт би тэдэнд үзүүлэх болно.

29 Мөн би, Моронай, эдгээр үгсийг сонсоод, тайтгаруулагдаж, мөн хэлэв: Ай Их Эзэн, таны зөв шударга таалал гүйцэлдэх болтугай, учир нь та хүмүүний үрсэд тэдний итгэлийн дагуу үйлддэг билээ;

30 Учир нь Жаредын ах Зерин ууланд, “нүү хэмээн хэлэхэд — тэр нь нүүлгэгдсэн шүү дээ. Мөн хэрэв тэрээр итгэлгүй байсан бол тэр нь нүүхгүй байсан; иймийн тул хүмүүс итгэлийг агуулсны дараа л та үйлддэг шүү дээ.

31 Учир нь тийн та өөрийгөө шавь нартаа үзүүлсэн; учир нь тэд “итгэлийг агуулсны, мөн таны нэрээр ярьсны дараа, та өөрийгөө тэдэнд агуу хүчтэйгээр үзүүлсэн буюу.

32 Мөн түүнчлэн түүнд хүмүүн илүү онцгой “найдвар тавьж болох өргөөг та хүмүүнд, тийм ээ, таны Эцэгийн ⁹эзэмшлүүдийн дунд бэлтгэсэн хэмээн таны хэлснийг би санаж байна; иймийн тул хүмүүн найдах ёстой, эс бөгөөс тэрээр таны бэлтгэсэн тэр байранд өв хүртэж чадахгүй.

33 Мөн түүнчлэн, та дэлхийнхэнд “хайртай, бүр өөрийн амийг дэлхийнхний төлөө өгөх хүртлээ, хүмүүний үрсэд нэгэн байрыг бэлтгэхийн тулд үүнийг эргүүлж авна хэмээн хэлснийг тань би санаж байна.

34 Мөн эдүгээ хүмүүний үрсэд зориулсан таны “хайр бол энэрэл гэдгийг би мэднэ; иймийн тул, хүмүүс энэрэлтэй байхаас бусдаар, Эцэгийнхээ эзэмшлүүдэд таны бэлтгэсэн тэрхүү байрыг өвлөж чадахгүй.

35 Иймийн тул, бидний сул доройн улмаас, хэрэв харийнхан энэрэл үгүй аваас, та тэднийг сорьж, мөн тэдний “талантыг нь авч, тийм ээ, бүр тэдний хүлээн авсан түүнийг нь, мөн илүү элбэг хангалуун буй тэдэнд өгөх болно хэмээн таны хэлсэн энэ зүйлээр би мэднэ.

36 Мөнхүү улиран тохиох дор

276 су Ач ивээл.
 в Лук 18:10–14;
 С ба Г 1:28.
 су Даруу, Даруу байдал.
 з Лук 9:46–48;
 2 Кор. 12:9.
 д Ег. 4:11; 1 Кор. 1:27.

28a 1 Кор. 13:1–13;
 Моро. 7:39–47.
 30a Мат. 17:20;
 Иаков 4:6;
 Хил. 10:6, 9.
 су Хүч.
 31a су Итгэл.
 32a су Найдвар.

б Иохан 14:2;
 Инос 1:27;
 С ба Г 72:4; 98:18.
 33a Иохан 3:16–17.
 34a Моро. 7:47.
 су Энэрэл; Хайр.
 35a Мат. 25:14–30.
 су Бэлэг; Авьяас.

тэд энэрлийг агуулж болохын тулд, тэрээр харийнханд “ач ивээлийг хайрлаасай хэмээн Их Эзэнд хандан залбирсан буюу би.

37 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн надад хэлрүүн: Хэрэв тэд энэрэл үгүй аваас, энэ нь чамд хамаагүй болой; чи итгэлтэй байсан; иймийн тул, чиний өмсгөл “цэвэр болгогдох болно. Мөн чи өөрийн ^бсул доройг харсны учир чи, миний Эцэгийн эзэмшилд миний бэлтгэсэн байранд суух хүртэл хүчирхэг болгогдох болно.

38 Мөн эдүгээ, би, Моронай, харийнханд, тийм ээ, мөн түүнчлэн өөрийн хайрладаг ах дүүстээ, миний “өмсгөлүүдэд та нарын цусны толбо үгүйг бүх хүмүүс мэдэх Христийн ^бшүүлтийн суудлын өмнө бид уулзах хүртэл сайныг ерөөе.

39 Мөн би Есүсийг “харсан, мөн нэг хүмүүн нөгөөдөө хэлэхийн адилаар, тэрээр надтай ^бнүүр тулан ярьсан, мөн тэрээр энгийн даруу байдлаар, миний хэлээр эдгээр зүйлүүдийн талаар хэлснийг тийн та нар мэдэх болно;

40 Мөн миний бичих нь сул доройн улмаас, би зөвхөн цөөн хэдийг бичсэн бөлгөө.

41 Мөн эдүгээ, Бурхан Эцэгийн мөн түүнчлэн Их Эзэн Есүс Христийн, мөн тэднийг

“гэрчилдэг Ариун Сүнсний ач ивээл та нарт оршин байж мөн үүрд үлдэхийн тулд бошиглогчид хийгээд төлөөлөгчдийн тухайлан бичсэн Есүсийг ^бэрэлхийлэхийг би та нарт уриалж байна. Амен.

БҮЛЭГ 13

Иосефын үр удмаар Америкт баригдах Шинэ Иерусалимын талаар Ифер ярьж байв—Тэрбээр бошиглож, хөөгдөн, жаредчуудын түүхийг бичиж, мөн жаредчуудын устгалыг зөгнөн хэлэв—Бүх нутаг даяар дайн ширүүсэв.

Мөн эдүгээ, би, Моронай, өөрийн бичиж асан хүмүүсийн устгалын талаарх өөрийн цэдгийг дуусгахаа үргэлжлүүлэе.

2 Учир нь болгоогтун, тэд Иферийн бүх үгсийг эсэргүүцсэн бөлгөө; учир нь хүмүүний эхлэлээс эхлэн бүх зүйлийн тухай; мөн энэ нутгийн гадаргуугаас ус “ширгэсний дараа энэ нь бусад бүх нутгийн дээгүүр сонгомол нутаг, Их Эзэний сонгосон нутаг болсныг; иймийн тул Их Эзэн үүний гадаргуу дээр оршин суусан бүх хүмүүс өөрт нь ^бүйлчлээсэй хэмээснийг тэрээр үнэнээр хэлсэн буюу;

3 Мөн энэ нь тэнгэрээс

36a су Ач ивээл.

37a С ба Г 38:42;

88:74–75; 135:4–5.

б Ифер 12:27.

38a Иаков 1:19.

б су Есүс Христ—

Шүүгч.

39a су Есүс Христ—

Христийн мөнх бус амьдралын дараах ирэлт.

б Эхл. 32:30; Ег. 33:11.

41a 3 Ниф. 11:32.

б С ба Г 88:63; 101:38.

13 2a Эхл. 7:11–24; 8:3.

б Ифер 2:8.

“бууж ирэхийг, ⁶Шинэ Иерусалимын, мөн Их Эзэний ариун дуганы газар болохыг.

4 Болгоогтун, Ифер Христийн өдрүүдийг харж, мөн тэрээр энэ нутаг дээрх “Шинэ Иерусалимын талаар ярьсан буюу.

5 Мөн тэрбээр түүнчлэн Израилын угсааны, мөн “Лихайн тэндээс ирэх тэр ⁶Иерусалимын талаар ярьж байв—энэ нь устгагдсаны дараа, Их Эзэний тулд ⁶ариун хот болон дахин баригдах болно; иймийн тул, энэ нь хуучны цагт байсан учир шинэ Иерусалим байх аргагүй юм; гэвч энэ нь дахин баригдана, мөн Их Эзэний тулд ариун хот болно; мөн энэ нь Израилын угсааны төлөө баригдах болно—

6 Мөн “Шинэ Иерусалим энэ нутагт, ⁶Иосефын үр удмын үлдэгдлийн тулд баригдах болно, учир нь тэдгээр зүйлүүдийн “хэв шинж юм.

7 Учир нь, Иосеф өөрийн эцгийг доош “Египетийн нутагт авчирсанчлан, тэрээр тийн тэнд нас нөгчсөн; иймийн тул, тэр эрсдэхгүйн тулд Иосефын эцэгт тэрээр нигүүлсэнгүй байсныхаа адилаар, Иосефын үрсэд, тэд ⁶эрсдэхгүйн тулд тэрээр тэнд нигүүлсэнгүй байх учир

Их Эзэн Иосефын үр удмын нэгэн үлдэгдлийг Иерусалимын нутгаас гарган авчирсан буюу.

8 Иймийн тул, Иосефын угсааны үлдэгдэл энэ “нутагт төвхнүүлэгдэх болно; мөн энэ нь тэдний өвийн нутаг байх болно; мөн тэд, эртний Иерусалимын адилаар, Их Эзэний тулд ариун хот босгох болно; мөн дэлхий эцэслэх үед ирэх тэрхүү төгсгөл хүртэл тэд ⁶дахин бусниулагдахгүй.

9 Мөн “шинэ тэнгэр мөн шинэ дэлхий байх болно; мөн тэдгээр нь хуучин нь эцэслэж, мөн бүх зүйл шинэ болсноос бусдаар хуучинтайгаа адил байх болно.

10 Мөн тэгээд Шинэ Иерусалим ирнэ; мөн тэнд оршин суух тэд адислагдсан болой, учир нь Хурганы цусаар өмсгөлүүд нь “цагаан болгогдсон нь тэд юм; мөн тэд бол Израилын угсааных болох, Иосефын үр удмын үлдэгдэл дунд тоологдох тэд юм.

11 Мөн тэгээд түүнчлэн хуучны Иерусалим ирэх болно; мөн түүний оршин суугчид, тэд адислагдсан болой, учир нь тэд Хурганы цусанд угаагдсан юм; мөн тэд бол тараагдаж мөн дэлхийн дөрвөн

3а Илч. 3:12; 21:2.

б 3 Ниф. 20:22;
21:23–24.

сү Шинэ
Иерусалим.

4а сү Сион.

5а 1 Ниф. 1:18–20.

б сү Иерусалим.
в Илч. 21:10;

3 Ниф. 20:29–36.

6а С ба Г 42:9; 45:66–67;
84:2–5; ИТ 1:10.

б сү Иосеф, Иаковын
хүү.

в Алма 46:24.

сү Бэлэгдлийн.

7а Эхл. 46:2–7; 47:6.

б 2 Ниф. 3:5.

8а сү Амлалтын нутаг.

б Моро. 10:31.

9а 2 Петр 3:10–13;

Илч. 21:1;

3 Ниф. 26:3;

С ба Г 101:23–25.

10а Илч. 7:14;

1 Ниф. 12:10–11;

Алма 5:27.

зүгээс, мөн “умард улсуудаас⁶ цуглуулагдсан, мөн Бурхан тэдний эцэг “Абрахамтай хийсэн гэрээний биелэлтийг хүртэгсэд болох тэд юм.

12 Мөн эдгээр зүйлс ирэхдээ, “эхэнд байсан, эцэст байх тэд гэж бий; мөн эцэст байсан, эхэнд байх тэд гэж бий хэмээн өгүүлэх судрыг улиран тохиолгох буюу.

13 Мөн би илүүг бичихээр зэхэж байв, гэвч би хориглогдсон юм; гэвч Иферийн бошиглолууд агуу хийгээд гайхамшигтай байсан бөлгөө; гэвч тэд түүнийг юу ч биш мэт үнэлсэн, мөн түүнийг хөөн зайлуулсан; мөн тэрээр өдөр нь өөрийгөө хадан агуйд нууж, мөн шөнө нь тэрээр явж хүмүүсийн дээр тохиох зүйлийг хардаг байв.

14 Мөн хүмүүсийн дээр ирсэн устгалуудыг шөнөөр хараад, тэрээр хадан агуйд амьдарч байхдаа тэрээр энэхүү цэдгийн үлдэгдлийг хийсэн ажээ.

15 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүмүүсийн дундаас зайлуулагдсан тэр жил хүмүүсийн дунд агуу дайн эхлэв, учир нь боссон нь, мөн урьд яригдаж асан тэдний ёс бусын үйлийн нууц төлөвлөгөөгөөр Кориантумыг устгахаар эрэлхийлж байсан нь олон байв, мөн тэдгээр нь хүчит эрчүүд байв.

16 Мөн эдүгээ Кориантумр,

өөрөө дайны бүх аргад мөн дэлхийн бүх башир аргад суралцжээ, иймийн тул өөрийг нь устгахаар эрэлхийлсэн тэдэнтэй тэр тулаанд оров.

17 Гэвч, тэрбээр наманчилсан нь үгүй, бас түүний хонгорхон охид мөн хөвгүүд ч тэгсэнгүй; мөн Кохорын хонгорхон охид мөн хөвгүүд ч тэгсэнгүй; Корихорын хонгорхон охид мөн хөвгүүд ч тэгсэнгүй; мөн эцэст нь бүх дэлхийн гадаргуу дээр нүглүүдээ наманчилсан хонгорхон охид мөн хөвгүүд нэг ч байсангүй.

18 Иймийн тул, улиран тохиох дор Ифер хадан агуйд оршин суусан эхний жилд, тэд хаант улсыг олж авахын тулд Кориантумын эсрэг тулалдаж асан тэдгээр “нууц хуйвалдаануудын илдээр хөнөөгдсөн нь олон байв.

19 Мөнхүү улиран тохиох дор Кориантумын хөвгүүд их тулалдаж мөн их цус урсав.

20 Мөн хоёр дахь жилд Их Эзэний үг Иферт ирж, хэрэв тэрбээр мөн түүний бүх гэр бүлийнхэн наманчлах аваас, Их Эзэн түүнд хаант улсыг нь өгч мөн уг хүмүүсийг хэлтрүүлэх болохыг тэрбээр явж мөн, “Кориантумрт ийн бошиглохыг хэлэв—

21 Эс бөгөөс тэд, мөн түүнээс бусад бүх л гэр бүлийнхэн нь устгагдах болно. Мөн тэдний өвийн нутгийг хүлээн

11а С ба Г 133:26–35.

б су Израил—
Израилын
цугларалт.

в су Абрахамын гэрээ.

12а Марк 10:31;
1 Ниф. 13:42;
Иаков 5:63;

С ба Г 90:9.

18а Ифер 8:9–26.
20а Ифер 12:1–2.

авах талаар хэлэгдсэн бошиг-
лолын биелэлийг зөвхөн үзэ-
хийн тулд тэрбээр “өөр хү-
мүүс амьд үлдэх болно; мөн
Кориантумр тэднээр оршуу-
лагдах болно; мөн ⁶Кориан-
тумраас бусад бүх бодгаль
устгагдах болно.

22 Мөнхүү улиран тохиох дор
Кориантумр, түүний гэр
бүлийнхэн ч бас наманчил-
сангүй, мөн уг хүмүүс ч бас
тэгсэнгүй; мөн дайнууд зогс-
сонгүй; мөн тэд Иферийг ала-
хыг эрэлхийлэв, гэвч тэрээр
тэдний өмнө зугтан мөн да-
хин хадан агуйд нуугдав.

23 Мөнхүү улиран тохиох дор
Шаред босч, мөн тэрээр Ко-
риантумртай тулаанд оров;
мөн тэрбээр түүнийг дийлж,
үүний хэрээр гурав дахь
жилд тэрбээр түүнийг боолч-
лолд оруулав.

24 Мөн Кориантумрын хөв-
гүүд, дөрөв дэх жилд, Шаред-
дийг дийлж, мөн эцэгтээ
хаант улсыг нь буцаан авч
өгсөн бөлгөө.

25 Эдүгээ нутгийн бүх га-
даргуу дээр дайн эхлэв,
хүмүүн бүр бүлэглэлийнхээ
хамт хүссэнийхээ төлөө дай-
тах ажгуу.

26 Мөн дээрэмчид байв, мөн
эцэст нь, нутгийн бүх гадар-
гуу дээр бүх төрлийн ёс бу-
сын үйл байв.

27 Мөнхүү улиран тохиох дор
Кориантумр Шаредад үлэмж
хилэгнэн, мөн тэрбээр түү-
ний эсрэг их цэрэгтэйгээ ту-
лалдаанд явав; мөн тэд агуу

хилэнтэйгээр тулгарч, мөн
тэд Гилгалын хөндийд тул-
гарсан бөлгөө; мөн тулалдаан
үлэмж ширүүн болов.

28 Мөнхүү улиран тохиох дор
Шаред түүний эсрэг гурван
өдрийн турш тулалдсан аж.
Мөнхүү улиран тохиох дор
Кориантумр түүнийг дийлж,
мөн тэрбээр Хешлоны тал
газруудад ирэх хүртэл түү-
нийг үлдэн хөөв.

29 Мөнхүү улиран тохиох дор
Шаред тал газруудад түүн-
тэй дахин тулалдаанд оров;
мөн болгоогтун, тэр Кориан-
тумрыг дийлж, мөн түүнийг
Гилгалын хөндийд ортол нь
гэдрэг ухраав.

30 Мөн Гилгалын хөндийд
Кориантумр дахин Шаред-
тай тулалдаанд оров, тэгс-
нээр Шаредыг дийлж мөн
түүнийг хөнөөв.

31 Мөн Шаред Корионтум-
рыг гуянд нь шархдуулснаас,
тийнхүү тэр хоёр жилийн
турш дахин тулалдахаар яв-
сангүй, тэр хугацаанд нут-
гийн гадаргуу дээрх бүх хү-
мүүс цус урсаж, мөн тэднийг
зогсоох хэн ч үгүй байв.

БҮЛЭГ 14

*Хүмүүсийн алдас уг нутагт
зүхэл авчрав—Кориантумр Ги-
лиад, дараа нь Либ, тэгээд Ши-
зийн эсрэг дайнд оров—Цус мөн
хядаан уг нутгийг бүрхэв.*

Мөн эдүгээ бүх нутагт хү-
мүүсийн алдсын улмаас агуу

“зүхэл байж эхлэв, тэгснээр, хэрэв хүмүүн өөрийн багаж эсвээс илдээ тавиур дээрээ, эсвээс тэрбээр үүнийг хаа хадгалах тэр газраа тавих аваас, болгоогтун, маргааш өдөр нь тэрбээр үүнийг олж чадахгүй байв, уг нутгийн дээрх зүхэл тийм агуу байв.

2 Иймийн тул хүмүүн бүр өөрийнх болох түүнийг, гартаа чанга атгаж, мөн зээлэхгүй бас зээлүүлэхгүй байв; мөн хүмүүн бүр, өөрийн өмч болон өөрийн эхнэр мөн хүүхдүүдийнхээ амийг хамгаалахын тулд, илднийхээ бариулыг баруун гартаа атгаж байв.

3 Мөн эдүгээ, хоёр жилийн дараа, мөн Шаредын үхлийн дараа, болгоогтун, Шаредын дүү босож мөн тэрбээр Кориантумртай тулалдаанд оров, түүгээр Кориантумр түүнийг дийлж мөн Акишийн аглаг буйд хүртэл түүнийг үлдэн хөөв.

4 Мөнхүү улиран тохиох дор Шаредын дүү Акишийн аглаг буйдад түүнтэй тулалдаанд орсон аж; мөн тулалдаан үлэмж ширүүн болж, мөн олон мянга нь илдээр унагаагдав.

5 Мөнхүү улиран тохиох дор Кориантумр аглаг буйдад бүслэн хаав; мөн Шаредын дүү шөнөөр аглаг буйдаас алхан гарч, мөн тэднийг согтуу байхад нь, Кориантумрын цэргүүдийн хэсгийг хөнөөв.

6 Мөн тэрбээр Мороны ну-

тагт ирж, мөн Кориантумрын хаан сэнтийд өөрийгөө залав.

7 Мөнхүү улиран тохиох дор Кориантумр өөрийн их цэрэгтэй аглаг буйдад хоёр жилийн турш оршин суув, ингэснээр тэрбээр өөрийн их цэрэгт агуу нэмэлт хүч хүлээн авчээ.

8 Эдүгээ, нэр нь Гилад болох, Шаредын дүү, нууц хуйвалдааны улмаас, их цэрэгтээ агуу нэмэлт хүч хүлээн авсан ажгуу.

9 Мөнхүү улиран тохиох дор түүнийг тэрбээр хаан сэнтийд заларч байхад нь дээд санваартан нь түүнийг хөнөөв.

10 Мөнхүү улиран тохиох дор нууц хуйвалдагчдын нэг түүнийг нууц гарцанд хөнөөв, мөн өөртөө хаант улсыг олж авав; мөн түүний нэр Либ байлаа; мөн Либ, бүх хүмүүсийн дундах аливаа бусад эрчүүдээс илүү агуу том биетэй хүн байв.

11 Мөнхүү улиран тохиох дор Либийн эхний жилд, Кориантумр Мороны нутагт өгсөн ирж, мөн Либтэй тулалдаанд оров.

12 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Либтэй тулалдаж, тэгснээр Либ түүний гарыг цохьсноос тэрбээр шархдав; гэсэн хэдий ч, Кориантумрын их цэрэг Либийг довтлон шахсанаас, тэрбээр тэнгисийн эргийн хил тийш зугтсан ажээ.

13 Мөнхүү улиран тохиох дор Кориантумр түүнийг үлдэн хөөв; мөн Либ тэнгисийн

эрэг дээр түүнтэй тулалдаанд оров.

14 Мөнхүү улиран тохиох дор Либ Кориантумрын их цэргийг дийлснээс, тэд дахин Акишийн аглаг буйд хүртэл зугтсан болой.

15 Мөнхүү улиран тохиох дор Либ түүнийг Агошийн тал газар очих хүртэл үлдэн хөөв. Мөн Коринтумр Либийн өмнө зугтаж явахдаа зугтан очсон уг нутгийн тэр хэсгийн бүх хүмүүсийг авч явав.

16 Мөн тэрбээр Агошийн тал газарт ирээд Либтэй тулалдаанд орж, мөн тэрбээр түүнийг үхтэл нь цохьсон ажгуу; гэсэн хэдий ч, Либийн дүү түүний оронд Кориантумрын эсрэг ирж, мөн уг тулалдаан үлэмж ширүүн болов, үүнд Кориантумр дахин Либийн дүүгийн их цэргийн өмнө зугтав.

17 Эдүгээ Либийн дүүгийн нэр нь Шиз хэмээгддэг байв. Мөнхүү улиран тохиох дор Шиз Кориантумрын араас үлдэн хөөж, мөн тэрбээр олон хотыг эзлэн авч, мөн тэрбээр эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийг түүнчлэн хөнөөж, мөн тэрбээр хотуудыг шатаасан ажээ.

18 Мөн бүх нутгаар Шизээс эмээх айдас тархав; тийм ээ, нутаг даяар нэг шуугиан тархав — Хэн Шизийн их цэргийн өмнө зогсож чадах билээ? Болгоогтун, тэрбээр өмнөө буй газар дэлхийг хүйс тэмтэрч байна!

19 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс, нутгийн бүх гадаргуу даяар, их цэрэгт нэгдэн цугларч эхлэв.

20 Мөн тэд хуваагдсан байлаа; мөн тэдний нэг хэсэг нь Шизийн их цэрэгт зугтан очиж, мөн тэдний нэг хэсэг нь Кориантумрын их цэрэгт зугтан очив.

21 Мөн уг нутгийн бүх гадаргуу үхэгсдийн “хүүрээр бүрхэгдэхээр, дайн тийм агуу хийгээд удаан болж, мөн удаан хугацааны турш урсах цус болоод хядааны талбар байв.

22 Мөн нас барагсдаа оршуулах хэн ч үлдсэнгүй, дайн тийм яаруу мөн хурдтай байж, харин тэд, уг нутгийн гадаргуу дээр тархсан эрчүүд, эмэгтэйчүүд, мөн хүүхдүүдийн хүүрийг махны “өт хорхойд улай болгохоор орхин, цус урсгалтаас цус урсгалтанд жагсан явж байлаа.

23 Мөн үүний үнэр нутгийн бүх гадаргуу дээр, бүр бүх нутгийн гадаргуу дээр тархсан байлаа; иймийн тул үүний үнэрийн улмаас, хүмүүс өдрөөр мөн шөнөөр балмагдсан байв.

24 Гэсэн хэдий ч, Шиз Кориантумрыг үлдэн хөөхөө зогссонгүй; учир нь, Кориантумр илдээр унагаагдахгүй хэмээн Иферт ирсэн Их Эзэний үгний улмаас, мөн хөнөөгдсөн ахынхаа цусны өшөөг Кориантумраас авахаар

тэрээр өөртөө тангарагласан байв.

25 Мөн тийн Их Эзэн тэнд өөрийн бүрэн хилэнгээр зочилж, мөн тэдний ёс бус үйл мөн жигшүүрт хэргүүд тэднийг үүрдийн устгалд хүрэх замыг бэлтгэснийг бид харав.

26 Мөнхүү улиран тохиох дор Шиз Кориантумыг дорно зүг тийш, бүр тэнгисийн эргийн дэргэдэх хязгаарыг хүртэл хөөж, мөн тэрээр гурван өдрийн турш тэнд Шизтэй тулалдаанд оров.

27 Мөн хүмүүс айж эхлэн, мөн Кориантумын их цэргийн өмнө зугтаж эхлэхээр Шизийн их цэргийн дундах устгал тийм аймшигтай байв; мөн тэд Корихорын нутагт зугтан, мөн тэдний өмнөх оршин суугчдыг, тэдэнтэй нэгдэхээс татгалзсан бүгдийг хүйс тэмтрэв.

28 Мөн тэд Корихорын хөндийд майхнуудаа босгов; мөн Кориантумр майхнуудаа Шуррын хөндийд босгов. Эдүгээ Шуррын хөндий Комнорын толгойн ойр байв; иймийн тул, Кориантумр их цэргээ Комнорын толгод дээр цуглуулж, мөн Шизийн их цэрэгт, тэднийг тулалдаанд дуудахаар бүрээ үлээв.

29 Мөнхүү улиран тохиох дор тэд хүрч ирж, гэвч гэдрэг ухраагдав; мөн тэд хоёр дахь удаагаа ирж, мөн тэд буцаан хоёр дахь удаагаа гэдрэг ухраагдсан бөлгөө. Мөнхүү

улиран тохиох дор тэд дахин гурав дахь удаагаа ирж, мөн тулалдаан үлэмж ширүүн болов.

30 Мөнхүү улиран тохиох дор Шиз Кориантумыг цохсноос түүнийг олон гүн шархтай болгосон аж; мөн Кориантумр, цус алдсанаас, ухаан алдан, мөн тэрээр үхсэн мэт өргүүлэн хүргэгджээ.

31 Эдүгээ Кориантумын их цэргийг үлдэн хөөхгүй байхыг Шиз өөрийн хүмүүст зарлиглахуйц, аль аль талд нь эрчүүд, эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийн алдагдал тийм агуу байв; иймийн тул, тэд буудалдаа буцав.

БҮЛЭГ 15

Сая сая жаредчууд тулалдаанд хөнөөгдөв—Шиз Кориантумр хоёр бүх хүмүүсийг үхлийн тулаанд цуглуулав—Их Эзэний Сүнс тэдний төлөө зүтгэхээ болив—Жаред үндэстэн бүрмөсөн устгагдав—Ганцхан Кориантумр үлдэв.

Мөнхүү улиран тохиох дор Кориантумр шархнаасаа эдгээд, тэрбээр өөрт нь хандан Иферийн хэлсэн “үгсийг санаж эхлэв.

2 Тэрбээр хэдийн өөрсдийнх нь хоёр сая шахам хүмүүс илдээр хөнөөгдсөнийг харж, мөн тэрбээр зүрх сэтгэлдээ гашуудаж эхлэв; тийм ээ, хүчит эрчүүд, мөн түүнчлэн тэдний эхнэрүүд, мөн

тэдний хүүхдүүдээс хоёр сая нь хөнөөгдсөн байв.

3 Тэрбээр хилэнцээ наманчилж эхлэв; тэрбээр бүх бошиглогчдын амаар хэлэгдсэн үгсийг санаж эхлэв, мөн тэрбээр, тэдгээр нь өдийг хүртэл, нэг бүрчлэн биелэгдсэнийг ухаарав; мөн түүнийг сэтгэл гашуудан мөн тайтгаруулагдахаас татгалзав.

4 Мөнхүү улиран тохиох дор, тэрбээр хүмүүсийг хэлтрүүлэх аваас, хүмүүсийн амийн төлөө тэрбээр хаант улсаа өгөх болно хэмээн хүсч тэрбээр Шизэд захидал бичив.

5 Мөнхүү улиран тохиох дор Шиз түүний захидлыг хүлээн аваад тэрбээр, хэрэв тэрбээр түүнийг өөрийнх нь илдээр хөнөөж болохын тулд тэрбээр өөрийгөө өгөх аваас, хүмүүсийн амийг тэрээр хэлтрүүлэх болно хэмээх захидлыг Кориантумрт бичжээ.

6 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс алдсаа наманчилсангүй; мөн Кориантумын хүмүүс Шизийн хүмүүсийн эсрэг уур хилэнд өдөөн хатгагдав; мөн Шизийн хүмүүс Кориантумын хүмүүсийн эсрэг уур хилэнд өдөөн хатгагдав; иймийн тул, Шизийн хүмүүс Кориантумын хүмүүсийн эсрэг тулалдаанд оров.

7 Мөн Кориантумр унах гэж буйгаа үзээд тэрбээр Шизийн хүмүүсийн өмнө дахин зугтав.

8 Мөнхүү улиран тохиох дор

тэрбээр, хөрвүүлбээс том, эсвэл бүгдээс нэт гэгдэх, Риплианкумын усанд ирэв; иймийн тул, тэд энэ усанд ирээд майхнуудаа босгов; мөн Шиз түүнчлэн тэдэнд ойрхон майхнуудаа босгов, мөн тиймийн тул маргааш нь тэд тулалдаанд оров.

9 Мөнхүү улиран тохиох дор тэд үлэмж ширүүн тулалдаанд тулалдаж, тэгснээр Кориантумр дахин шархдаж, мөн тэрбээр цус алдсанаас ухаан алдав.

10 Мөнхүү улиран тохиох дор Кориантумын их цэрэг Шизийн их цэргийг довтлон шахсанаас, тэднийг дийлж, тэднийг өөрсдийн өмнө зугтах болгов; мөн тэд өмнө зүг зугтаж, мөн Огаф хэмээн нэрлэгдэх газар майхнуудаа босгов.

11 Мөнхүү улиран тохиох дор Кориантумын их цэрэг Рама толгойн хажууд майхнуудаа босгов; мөн миний эцэг Мормон ариун нандин цэдгүүдийг Их Эзэний тулд “нуусан тэрхүү толгой бөлгөө.

12 Мөнхүү улиран тохиох дор тэд нутгийн бүх гадаргуу дээрх, хөнөөгдөөгүй асан, Иферээс бусад бүх хүмүүсийг нэгтгэн цуглуулав.

13 Мөнхүү улиран тохиох дор Ифер хүмүүсийн бүх үйлдлийг харсан аж; мөн Кориантумын талд байсан хүмүүс Кориантумын их цэрэгт нэгдэн цугларсныг; мөн Шизийн талд байсан хүмүүс

Шизийн их цэрэгт нэгдэн цугларсныг тэрээр болгоов.

14 Иймийн тул, тэд уг нутгийн гадаргуу дээр байсан бүгдийг авч болохын тулд, мөн тэд хүлээн авч болох бүх нэмэлт хүчийг тэд хүлээн авч болохын тулд, тэд дөрвөн жилийн турш хүмүүсийг нэгтгэн цуглуулж байв.

15 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгдээрээ, хүн бүр дуртай их цэрэгтээ, эхнэр мөн хүүхдүүдтэйгээ нэгдэн цугларсны дараа — эрчүүд, эмэгтэйчүүд мөн хүүхдүүд аль аль нь дайны зэвсгээр зэвсэглэн, бамбай, мөн “цээжний хуяг, мөн толгойн дуулга агсан, мөн дайны байдлаар хувцаслан — тэд нэг нэгнийхээ эсрэг тулалдахаар давшив; мөн тэд тэр өдөржингөө дайтав, мөн ялсан нь үгүй.

16 Мөнхүү улиран тохиох дор шөнө болоход тэд ядарч, мөн буудлууддаа гэдрэг ухрав; мөн буудалдаа ухарсны дараа тэд өөрсдийн хүмүүсээс алагдагсдын хохирлын учир орь дуу тавин мөн гаслав; мөн тэд агаарыг үлэмж доргиохоор тэдний уйлаан, тэдний орь дуу тавилт гаслан хийгээд тийм агуу байв.

17 Мөнхүү улиран тохиох дор маргааш нь тэд дахин тулалдахаар явж, мөн тэр өдөр агуу хийгээд аймшигтай байсан ажгуу; гэсэн хэдий ч, тэд ялсангүй, мөн дахин шөнө ирэхэд тэд өөрсдийн хүмүүсээс алагдагсдын хохирлын учир,

тэд уйлаан, мөн орь дуу тавилт, мөн гаслангаараа агаарыг доргиов.

18 Мөнхүү улиран тохиох дор, тэрбээр дахин тулалдаанд орохгүй, харин тэрбээр хаант улсыг авч, мөн хүмүүсийнх нь амийг хэлтрүүлээч хэмээн хүссэн захидлыг Шизэд Кориантумр бичив.

19 Гэвч болгоогтун, Их Эзэний Сүнс тэдний төлөө зүтгэхээ больсон байв, мөн “Сатан хүмүүсийн зүрх сэтгэлийн дээр бүрэн хүчийг агуулж байв; учир нь тэд өөрсдөө устгагдаж болохын тулд зүрх сэтгэлийнхээ хатууд, мөн оюун санааныхаа харалганд автагдсан байв; иймийн тул тэд дахин тулалдахаар явав.

20 Мөнхүү улиран тохиох дор тэд өдөржингөө тулалдан, мөн шөнө ирэхэд тэд илдээ дэрлэн унтацгаав.

21 Мөн маргааш нь тэд бүр шөнө ирэх хүртэл тулалдав.

22 Мөн шөнө ирэхэд тэд уур хилэндээ, бүр дарсанд согтуурсан хүмүүний адилаар “согтсон байв; мөн тэд дахин илдээ дэрлэн унтацгаав.

23 Мөн маргааш нь тэд дахин тулалдав; мөн шөнө ирэхэд тэд Кориантумрын хүмүүсээс тавин хоёр, мөн Шизийн хүмүүсээс жаран есөөс бусад нь бүгд илдээр унагагдсан байв.

24 Мөнхүү улиран тохиох дор тэр шөнөдөө тэд илдээ дэрлэн унтаж, мөн маргааш нь тэд дахин тулалдав, мөн тэд

өөрсдийн илдтэйгээр мөн өөрсдийн бамбайтайгаар, тэр өдөржингөө бүх хүчээрээ тэмцэлдэв.

25 Мөн шөнө ирэхэд Шизийн хүмүүсээс гучин хоёр, мөн Кориантумын хүмүүсээс хорин долоо нь үлдсэн байв.

26 Мөнхүү улиран тохиох дор тэд идээд мөн унтав, мөн маргааш болох үхэлд бэлтгэцгээв. Мөн тэд хүмүүний хүч тэнхээний хувьд том бие-тэй мөн хүчит эрчүүд байв.

27 Мөнхүү улиран тохиох дор тэд гурван цагийн турш тулалдаж, мөн тэд цус алдан ухаан алдацгаав.

28 Мөнхүү улиран тохиох дор Кориантумын хүмүүс тэд алхаж чадах хангалттай хүч тамиртай болоод, тэд амиа хоохойлон зугтахаар завдаж байв; гэвч болгоогтун, Шиз, мөн түүний хүмүүс босон, мөн тэрээр Кориантумыг хөнөөнө эс бөгөөс өөрөө илдэнд үхнэ хэмээн тэрбээр уур хилэндээ тангараглав.

29 Иймийн тул, тэрбээр тэднийг хөөж, мөн маргааш өдөр нь тэрбээр тэднийг гүйцэж түрүүлэв; мөн тэд илдээрээ дахин тулалдав. Мөнхүү улиран тохиох дор тэд, Кориантумр Шиз хоёроос

бусад нь “бүгд илдээр унагагдсаны дараа, болгоогтун Шиз цус алдан ухаан алджээ.

30 Мөнхүү улиран тохиох дор хэсэг зуур амрахын тулд Кориантумр илдээ налаад, дараа нь тэрбээр Шизийн толгойг тас цавчив.

31 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Шизийн толгойг тас цавчсаны дараа, Шиз гар дээрээ өндийснөө мөн унав; мөн тэрбээр амьсгал авахаар нэг зүтгээд, үхэх нь тэр.

32 Мөнхүү улиран тохиох дор “Кориантумр газарт унан, мөн тэрбээр амьгүй мэт болов.

33 Мөн Их Эзэн Иферт хандан ярьж, мөн түүнд хэлрүүн: Гарч явагтун. Мөн тэрбээр гарч яваад, мөн Их Эзэний үгс бүгд биелэгдсэнийг болгоов; мөн тэрбээр “цэдгээ дуусгав; (мөн зууны нэгийг нь ч би эс бичсэн буюу) мөн тэрбээр Лимхайн хүмүүс тэдгээрийг олсон тэр байдлаар нь тэдгээрийг нуув.

34 Эдүгээ “Иферээр бичигдсэн сүүлчийн үгс нь эдгээр буюу: Их Эзэний тааллаар зөөгдөх үү, эс бөгөөс маханбодид түүний тааллыг тэвчих үү гэдэг нь хамаагүй, бибээр Бурханы хаант улсад аврагдах болтугай. Амен.

29a Ифер 13:20–21.

32a Омнай 1:20–22.

33a Мозая 8:9;

Алма 37:21–31;

Ифер 1:1–5.

34a Ифер 12:2.

Моронайн Ном

БҮЛЭГ 1

Леменчүүдийн сайн сайхны төлөө Моронай бичив—Христийг үгүйсгэхгүй нифайчууд үхэлд хүргэгдэв. Ойролцоогоор мэ 401–421 он.

ЭДҮГЭЭ би, “Моронай, Жаредын хүмүүсийн шастирыг хураангуйлахаа төгсгөл болгосныхоо дараа, би өөрийг бичнэ хэмээн бодсонгүй, гэвч би хараахан мөхөөгүй байна; мөн тэд намайг устгах вий хэмээн эмээж би өөрийгөө леменчүүдэд мэдүүлдэггүй.

2 Учир нь болгоогтун, өөрсдийнх нь дундах “дайнууд үлэмж хэрцгий; мөн тэдний үзэн ядалтын учир тэд Христийг үгүйсгэхгүй нифай үндэстэн болгоныг үхэлд хүргэдэг.

3 Мөн би, Моронай, Христийг “үгүйсгэх нь үгүй; иймийн тул, амь насныхаа аюулгүй байдлын төлөө боломжтой хаана ч болов би бэдрэн явдаг.

4 Иймийн тул, бодож байсныхаа эсрэгээр өөр цөөн хэдэн зүйлийг би бичье; учир нь би илүүг бичих болно хэмээн бодсонгүй; гэвч Их Эзэний тааллын дагуу, ирээдүйн нэг өдөр, леменчүүд, ах дүүст минь чухал байж магад хэмээх тул би өөр цөөн хэдэн зүйл бичье.

БҮЛЭГ 2

Ариун Сүнсний бэлэг өгөх хүчийг нифай үндэстэн арванхоёр шавьд есүс өгөв. Ойролцоогоор мэ 401–421 он.

Тэрбээр өөрийн сонгосон тэр арванхоёрын, толгой дээр гараа тавьж, “шавь нартаа өгүүлсэн, Христийн үгс оршвой—

2 Мөн тэрбээр тэднийг нэрээр нь дуудаж, хэлрүүн: Та нар миний нэрээр, хүчит залбирлаар Эцэгийг дуудах болно; мөн та нар үүнийг хийсний дараа толгой дээр нь “гараа тавьсан түүнд та нар Ариун Сүнс ^бөгөх “хүчтэй байх болно; мөн миний нэрээр та нар үүнийг өгөх болно, учир нь төлөөлөгчид минь тийн үйлддэг.

3 Эдүгээ Христ анхныхаа ирэлтийн үеэр тэдэнд эдгээр үгсийг хэлсэн юм; мөн цугласан олон үүнийг сонссонгүй, гэвч шавь нар нь үүнийг сонссон бөлгөө; мөн тэдний гараа “тавьсан болгоны дээр Ариун Сүнс буусан бөлгөө.

БҮЛЭГ 3

Ахлагчид дээр нь гар тавьснаар санваартнууд болон багш нарыг томилдог. Ойролцоогоор мэ 401–421 он.

[Моронай]

1 1а су Моронай,
Мормоны хүү.
2а 1 Ниф. 12:20–23.

б Алма 45:14.
3а Мат. 10:32–33;
3 Ниф. 29:5.
2 1а 3 Ниф. 13:25.

2а су Гар тавих.
б 3 Ниф. 18:37.
в су Хүч.
3а Үйлс 19:6.

Сүмийн “ахлагчид хэмээн нэрлэгдсэн тэрхүү шавь нар, санваартнууд болоод багш нарыг ⁶томилдог асан тэр маяг нь энэ буюу —

2 Тэдгээр нь Христийн нэрээр Эцэгт залбирсны дараа, тэд тэдний дээр гар тавьж мөн хэлэх нь:

3 Түүний нэрэнд төгсгөл хүртэл итгэн тэвчсэнээр, Есүс Христээр дамжин ирэх нүглүүдийн “ангижрал хийгээд наманчлалыг номлуулахаар би таныг санваартан (эсвээс хэрэв тэр багш байхаар бол, би таныг багш байхаар томилж байна) байхаар Есүс Христийн нэрээр томилж байна. Амен.

4 Мөн энэ маягаар тэд санваартнууд болон багш нарыг хүмүүнд өгөгдсөн Бурханы “бэлгүүд хийгээд дуудлагуудын дагуу томилдог байв; мөн тэд өөрсдөд нь орших, Ариун Сүнсний ⁶хүчээр тэднийг “томилдог байв.

БҮЛЭГ 4

Ахлагчид болон санваартнууд ариун ёслолын талхыг хэрхэн адислан түгээдэг нь тайлбарлагдав. Ойролцоогоор мэ 401–421 он.

“Ахлагчид болон санваарт-

нууд Сүмийнхэнд Христийн бие болон цусыг адислан түгээх ⁶хэлбэр нь; мөн тэд Христийн зарлигуудын дагуу үүнийг “адислан түгээдэг байв; иймийн тул бид уг хэлбэр нь үнэнийг мэднэ; мөн ахлагч эсвээс санваартан үүнийг адислан түгээдэг байв —

2 Мөн тэд сүмийнхэнтэй хамт сөгдөн сууж, мөн Христийн нэрээр Эцэгт залбирч, хэлдэг байв:

3 Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, үүнээс хүртэх тэд бүгдийн бодгалийн тулд; тэд түүний “Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж болохын тулд таны Хүүгийн биеийг ⁶төлөөлөн дурсаж, тэд үүнийг идэж, Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, тэд өөрсдөдөө таны Хүүгийн “нэрийг авч, мөн үргэлж түүнийг санаж, мөн өөрсдөд нь өгсөн түүний зарлигуудыг дагахад бэлэн гэдгээ танд гэрчилж болохын тулд, энэ ‘талхыг адисалж мөн ариусгахыг таны Хүү, Есүс Христийн нэрээр бид танаас гуйж байна. Амен.

БҮЛЭГ 5

Ариун ёслолын дарсыг адислан

3 1а Алма 6:1.
су Ахлагч.
б су Томилох,
Томилолт.
3а су Нүглүүдийн
ангижрал.
4а су Бэлэг.
б 1 Ниф. 13:37;

Моро. 6:9.
в С ба Г 18:32; 20:60.
4 1а су Ахлагч.
б 3 Ниф. 18:1–7.
в С ба Г 20:76–77.
3а су Ариун Сүнс.
б Лук 22:19;
1 Кор. 11:23–24;

3 Ниф. 18:7.
в су Есүс Христ—
Өөрсөд дээрээ
Есүс Христийн
нэрийг авах.
г су Ариун ёслол.

түгээх хэлбэр тайлбарлагдав. Ойролцоогоор мэ 401–421 он.

Дарсыг адислан түгээх “хэлбэр нь—Болгоогтун, тэд аяга авч, мөн хэлнэ:

2 Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, үүнээс уух тэд бүгдийн бодгалийн тулд, тэд түүний Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгаж болохын тулд, өөрсдийнх нь төлөө асгаруулсан таны Хүүгийн цусыг “төлөөлөн дурсаж, тэд үүнийг үйлдэж болохын тулд; Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, тэд үргэлж түүнийг санана гэдгээ танд гэрчилж болохын тулд, энэ ^бдарсыг адисалж, мөн ариулахыг таны Хүү Есүс Христийн нэрээр бид танаас гуйж байна. Амен.

БҮЛЭГ 6

Наманчлагч хүмүүс баптисм хүртэж мөн нөхөрлөцгөөв—Наманчилдаг сүмийн гишүүд өршөөгддөг—Цуглаанууд Ариун Сүнсний хүчээр удирдагддаг. Ойролцоогоор мэ 401–421 он.

Мөн эдүгээ би “баптисмын талаар ярья. Болгоогтун, ахлагч, санваартан мөн багш

нар баптисм хүртдэг байв; мөн тэд үүнд ^бзохистой байгаагаа үзүүлэхүйц үр жимс авчраагүй аваас тэд баптисм хүртдэггүй байв.

2 Бас тэд “харууссан зүрх болоод гэмшсэн сэтгэлтэйгээр ирж, мөн тэд бүх нүглүүдээ үнэхээр наманчилсныг сүмд гэрчлэхээс бусдаар бол тэд хэнийг ч баптисмд хүлээж авдаггүй байв.

3 Мөн тэд төгсгөл хүртэл түүнд үйлчлэх шийдвэртэйгээр, Христийн нэрийг өөрсөдөө “авсан тэднээс өөр хэн ч баптисмд хүлээн авагддаггүй байлаа.

4 Мөн тэд баптисмд хүлээн авагдсаны дараа, мөн Ариун Сүнсний хүчээр нөлөөлөгдөж мөн “цэвэршигдсэний дараа, тэд Христийн сүмийн хүмүүсийн дунд тоологддог байв; мөн тэднийг зөв замд байлгахын тулд, итгэлийнх нь ^бүүсгэгч мөн төгсгөгч нь болох Христийн сайн үйлсийн дээр л “тулгуурлан тэднийг залбиралд үргэлж ‘анхааралтай байлгахаар Бурханы сайн үгээр дурсагдан мөн тэжээгдэхийн учир тэдний ^бнэрс тэмдэглэгддэг байв.

5 Мөн “сүмийнхэн ^бмацаг

5 1а 3 Ниф. 18:8–11;
С ба Г 20:78–79.

2а Лук 22:19–20;

1 Кор. 11:25.

б С ба Г 27:2–4.

су Ариун ёслол.

6 1а су Баптисм,
Баптисм хүртээх.

б су Зөв зохистой,
Зөв зохистой

байдал.

2а су Харууссан зүрх.

3а су Есүс Христ—
Өөрсөд дээрээ Есүс
Христийн нэрийг
авах.

4а су Цэвэр ариун,

Цэвэр ариун

байдал.

б Евр. 12:2.

в 2 Ниф. 31:19;

С ба Г 3:20.

г Алма 34:39;

3 Ниф. 18:15–18.

д С ба Г 20:82.

5а су Есүс Христийн
Сүм.

б су Мацаг барих,
Мацаг барилт.

барихаар мөн залбирахаар, мөн өөр хоорондоо бодгалиудынхаа аз жаргалын талаар ярихаар ^аойр ойрхон цугладаг байв.

6 Мөн тэд Их Эзэн Есүсийг дурсан санаж талх, дарснаас хүртэхийн тулд цуглан ойр ойрхон цугладаг байв.

7 Мөн тэдний дунд ямар ч “алдас байхгүйн төлөө дагаж мөрдөхдөө чанд байв; мөн алдсыг үйлдсэн нь мэдэгдсэн хэн боловч, мөн сүмийн ^бгурван гэрч тэднийг ^аахлагч нарын өмнө ^вбуруушааж, мөн хэрэв тэд наманчлахгүй, мөн буруугаа тоочихгүй аваас, тэдний нэрс ^аарилгагдаж, мөн тэд Христийн хүмүүсийн дунд тоологддоггүй байв.

8 Харин тэд үнэн сэтгэлээсээ наманчилж мөн өршөөлийг эрэлхийлэх “болгондоо, тэд ^бөршөөгддөг байлаа.

9 Мөн цуглаанууд Сүнсний нөлөөний дагуу, мөн “Ариун Сүнсний хүчээр Сүмээр ^бхөтлөгддөг байв; учир нь Ариун Сүнсний хүч тэднийг номлоход, эсвээс ухуулахад, эсвээс залбирахад, эсвээс гуйхад, эсвээс дуулахад удирддагчлан, үүнчлэн тэр нь хийгддэг байв.

БҮЛЭГ 7

Их Эзэний амралтад орох урилга өгөгддөг — Үнэн сэтгэлээсээ залбир — Христийн Сүнс сайныг хилэнцтээс ялгаж мэдэх чадварыг хүмүүнд олгодог — Христийг үгүйсгэхийг мөн хилэнц үйлдэхийг Сатан хүмүүнд ятгадаг — Бошиглогчид Христийн ирэлтийг мэдүүлдэг — Итгэлээр гайхамигууд үйлдэдэг мөн тэнгэр элчүүд тохинуулдаг — Хүмүүн мөнх амьдралд найдан, энэрлээс зуурч авах ёстой. Ойролцоогоор мэ 401–421 он.

Мөн эдүгээ би, Моронай, “итгэл, найдвар, мөн энэрлийн талаар ярьсан өөрийн эцэг Мормоны үгсийн цөөн хэдийг бичье; учир нь шүтлэгийн газрын тулд тэдний барьсан синагогт тэрбээр тэдэнд зааж байхдаа тэрээр хүмүүст энэ маягаар ярьсан ажээ.

2 Мөн эдүгээ би, Мормон, хайрт ах дүү нар минь, та нарт ярья; мөн Бурхан Эцэг, мөн бидний Их Эзэн Есүс Христийн ач ивээлээр, мөн түүний ариун тааллаар, түүний надад өгсөн “дуудлагын бэлгийн учир, би энэ удаа та нарт ярих нь зөвшөөрөгдсөн билээ.

5в 3 Ниф. 18:22;

4 Ниф. 1:12;

С ба Г 88:76.

7а С ба Г 20:54.

б С ба Г 42:80–81.

су Гэрч.

в Алма 6:1.

су Ахлагч.

г су Хүлээн

зөвшөөрөх, Хүлээн

зөвшөөрөлт.

д Ег. 32:33;

С ба Г 20:83.

су Сүмээс хөөх.

8а Мозая 26:30–31.

б су Уучлах.

9а су Ариун Сүнс.

б С ба Г 20:45; 46:2.

7 1а 1 Кор. 13:1–13;

Ифер 12:3–22, 27–37;

Моро. 8:14; 10:20–23.

2а су Дуудах,

Бурханаас

дуудагдах,

Дуудлага.

3 Иймийн тул, би сүмийнх болох та нарт, Христийн амгалан дөлгөөн дагалдагчид болох та нарт, мөн энэ цагаас хойшид та нар тэнгэрт түүнтэй амрах болтлоо, Их Эзэний “амралтыг олж чадахаар хангалттай найдвар олж авсан та нарт ярья.

4 Мөн эдүгээ ах дүүс минь, та нар хүмүүний үрстэй хамт амгалан дөлгөөн “алхдагийн тань учир, та нарын талаар би эдгээр дүгнэлтэнд хүрэв.

5 Учир нь тэдний үйлүүдээр та нар тэднийг “мэдэх болно хэмээсэн Бурханы тэрхүү үгийг би санаж байна; учир нь хэрэв тэдний үйлс сайн байх аваас, тэгвэл тэд ч түүнчлэн сайн бөлгөө.

6 Учир нь болгоогтун, хүмүүн нь “хилэнцэт байваас сайн болох түүнийг үйлдэж чадахгүй гэж Бурхан хэлжээ; учир нь хэрэв тэр бэлэг өргөж, эсвээс Бурханд ^бзалбирлаа ч, тэрбээр үүнийг үнэн сэтгэлээсээ хийхгүй аваас, энэ нь түүнд ямар ч ашиггүй байх болно.

7 Учир нь болгоогтун, энэ нь түүний хувьд зөв шударга хэмээн тооцогдохгүй.

8 Учир нь болгоогтун, хэрэв “хилэнцэт нэгэн бэлэг өгвөөс, тэр үүнийгээ ^бдургүйгээр

үйлддэг; иймийн тул энэ нь түүний хувьд уг бэлгийг тэр авч үлдсэнтэй нэгэн адил тооцогддог; иймийн тул тэр Бурханы өмнө хилэнцэт хэмээн тооцогдох бөлгөө.

9 Мөн түүнчлэн үүний нэгэн адилаар хэрэв тэр залбирахдаа зүрх сэтгэлийнхээ “үнэн хүслээр бус аваас, энэ нь хүмүүнд хилэнцэт хэмээн тооцогдох ажгуу; тийм ээ, мөн энэ нь түүнд ямар ч ашиггүй, учир нь Бурхан тийм нэгийг ч хүлээн авдаггүй.

10 Иймийн тул, хилэнцэт болох хүмүүн нь сайн болох түүнийг хийж чадахгүй; бас тэрбээр сайн бэлэг ч өгөхгүй.

11 Учир нь болгоогтун, гашуун “эх булаг сайн усыг өгч чадахгүй; бас сайн эх булаг нь гашуун усыг өгдөггүй; иймийн тул, чөтгөрийн зарц болох хүмүүн Христийг дагаж чадахгүй; мөн хэрэв тэрбээр Христийг ^бдагавал тэр чөтгөрийн зарц байж чадахгүй.

12 Иймийн тул, “сайн болох бүх зүйл Бурханаас ирдэг; мөн ^бхилэнцэт болох тэр нь чөтгөрөөс ирдэг; учир нь чөтгөр Бурханы дайсан, мөн үргэлж түүний эсрэг тулалддаг, мөн ^бнүгэл үйлдэхэд, мөн хилэнцэтийг үйлдэхэд үргэлж урьж мөн татдаг буюу.

13 Гэвч болгоогтун, Бурханых

3а су Амрах.

4а 1 Иохан 2:6;

С ба Г 19:23.

5а 3 Ниф. 14:15–20.

6а Мат. 7:15–18.

б Алма 34:28.

су Залбирал.

8а Сур. үгс 15:8.

б С ба Г 64:34.

9а Иаков 1:6–7; 5:16;

Моро. 10:4.

11а Иаков 3:11–12.

б Мат. 6:24;

2 Ниф. 31:10–13;

С ба Г 56:2.

12а Иаков 1:17;

1 Иохан 4:1–2;

Ифер 4:12.

б Алма 5:39–42.

в Хил. 6:30.

су Нүгэл.

болох тэр нь үргэлж сайныг үйлдэхэд урьж мөн татдаг; иймийн тул, сайныг үйлдэхэд мөн Бурханыг хайрлахад, мөн түүнд үйлчлэхэд урьж мөн “татдаг тэрхүү юм бүр, Бурханаар ⁶нөлөөлөгддөг.

14 Иймийн тул, хайрт ах дүүс минь, та нар хилэнцэт болох тэр нь Бурханаас хэмээн, эсвээс сайн мөн Бурханаас болох тэр нь “чөтгөрөөс байдаг хэмээн бодохгүй байхыг анхаарагтун.

15 Учир нь болгоогтун, ах дүүс минь, та нар сайныг хилэнцтээс ялган мэдэж болохын тулд “дүгнэх нь та нарт өгөгдсөн билээ; мөн та нар төгс мэдлэгээр мэдэж болохын тулд дүгнэх арга нь өдрийн гэрэл, шөнийн харанхуйн ялгаа нь илэрхий байдаг лугаа адил тодорхой байдаг.

16 Учир нь болгоогтун, Христийн “Сүнс хүн бүрд тэрбээр сайныг хилэнцтээс ⁶ялган мэдэж болохын тулд өгөгдсөн байдаг, иймийн тул, би та нарт дүгнэх аргыг үзүүлье; учир нь Христэд итгүүлэхээр ятгахыг, мөн сайныг хийхийг урьдаг юм болгон нь, Христийн хүч болон бэлгээр илгээгдсэн байдаг; иймийн тул та нар энэ нь Бурханаас

гэдгийг төгс мэдлэгээр мэдэж болно.

17 Гэвч “хилэнцтийг хийхийг мөн Христэд үл итгэхийг, мөн түүнийг үгүйсгэхийг, мөн Бурханд эс үйлчлэхийг хүмүүнд ятгах юуг боловч, тэгвэл та нар энэ нь чөтгөрөөс гэдгийг төгс мэдлэгээр мэдэж болно; учир нь чөтгөр энэ маягаар ажилладаг, учир нь тэрбээр, бас түүний элчүүд ч гэсэн адил; бас түүнд өөрсдийгөө харъяалуулах тэд ч гэсэн сайныг хийхийг хүмүүнд ятгадаггүй, үгүй, хэнд ч үгүй.

18 Мөн эдүгээ, ах дүүс минь, түүгээр дүгнэж болох, Христийн “гэрэл болох тэрхүү гэрлийг та нар мэдэх учир, буруугаар дүгнэхгүй байхаа мэдэгтүн; учир нь та нар шүүх тэрхүү ⁶шүүлтээрээ түүнчлэн шүүгдэх болно.

19 Иймийн тул, ах дүүс минь, та нар сайныг хилэнцтээс ялган мэдэж болохын тул Христийн “гэрлээр шаргуу судлахыг би та нараас гуйя; мөн хэрэв та нар сайн зүйл болгоноос зууран барьж, мөн үүнийг үл буруушаах аваас, та нар гарцаагүй Христийн ⁶хүүхэд байх болно.

20 Мөн эдүгээ, ах дүүс минь, та нар сайн зүйл болгоноос

13а 2 Ниф. 33:4;
Ифер 8:26.
б су Сүнсний
удирдамж,
Сүнслэгээр
нөлөөлөгдөх.

14а Иса. 5:20;
2 Ниф. 15:20.

15а су Ялган таних бэлэг.

16а су Ухамсар; Гэрэл,
Христийн гэрэл.

б Эхл. 3:5;
2 Ниф. 2:5, 18, 26;
Мозая 16:3;
Алма 29:5;
Хил. 14:31.

17а су Нүгэл.
18а Мозая 16:9;

С ба Г 50:24; 88:7–13.
су Гэрэл, Христийн
гэрэл.

б исо, Мат. 7:1–2;
Лук 6:37; Иохан 7:24.
19а С ба Г 84:45–46.
б Мозая 15:10–12; 27:25.
су Бурханы хөвгүүд
оход.

барих нь яавал боломжтой байх вэ?

21 Мөн эдүгээ би итгэлийн тухай ярина хэмээсэн түүнийхээ тухай ярья; мөн та нар сайн юм болгоноос барьж болох замыг та нарт би хэльье.

22 Учир нь болгоогтун, үүрдээс үүрдэд оршихын учир, Бурхан бүх зүйлийг “мэдэхийн учир, болгоогтун, тэрбээр хүмүүний үрсэд тохинуулуулахаар, Христийн ирэлтийн талаар; мөн Христээр сайн юм болгон ирэхийг мэдүүлэхээр ⁶тэнгэр элчүүдийг илгээсэн болой.

23 Мөн түүнчлэн, Христ ирэх болно хэмээн зарлан Бурхан өөрийн амаар бошиглогчдод тунхагласан билээ.

24 Мөн болгоогтун, тэрбээр хүмүүний үрсэд сайн болох зүйлийг тунхагласан олон янзын аргууд байсан; мөн сайн болох бүх зүйл Христээс ирдэг; өөрөөр бол хүмүүн нь “унасан байсан, мөн тэдэнд ямар ч сайн зүйл ирэх аргагүй байсан билээ.

25 Иймийн тул, “тэнгэр элчүүдийн тохинууллаар, мөн Бурханы амнаас гарсан үг бүрээр, хүмүүн нь Христэд итгэх итгэлээ хөгжүүлж эхэлсэн юм; мөн тийн тэд итгэлээр, сайн юм болгоноос зууран барив; мөн энэ нь Христийн ирэлт хүртэл тийн байсан болой.

26 Мөн түүнийг ирсний дараа хүмүүн түүнчлэн түүний нэрэнд итгэх итгэлээр аврагдсан юм; мөн итгэлээр, тэд Бурханы хөвгүүд болно. Мөн Христ амьд нь гарцаагүйн адил тэрбээр эдгээр үгийг бидний эцэг өвгөдөд ярьсан, үүнд хэлрүүн: Та нар хүлээж авах болно хэмээн итгэх итгэлтэйгээр, миний нэрээр Эцэгээс гуйх, сайн болох “юм юу боловч, болгоогтун энэ нь та нарт хийгдэх болно.

27 Иймийн тул, хайрт ах дүүс минь, Христ тэнгэр өөд дээшлэн одсон, мөн хүмүүний үрсийн дээрх өөрийн нигүүлслийн эрхийг Эцэгээсээ “шаардахаар Бурханы баруун мутар талд суулаа гээд ⁶гайхамшгууд байхаа больсон гэж үү?

28 Учир нь тэрбээр хуулийн шаардлагуудыг хангасан, мөн тэрбээр өөрт итгэлтэй тэд бүгдийг шаарддаг; мөн түүнд итгэлтэй тэд сайн зүйл болгоноос “зууран барьдаг; иймийн тул тэрбээр хүмүүний үрсийн хэргийг ⁶өмгөөлдөг; мөн тэрбээр мөнхөд тэнгэрт оршдог.

29 Мөн тэрбээр үүнийг хийлээ гээд, хайрт ах дүүс минь, гайхамшгууд байхаа больсон гэж үү? Болгоогтун би та нарт хэлнэ, Үгүй; бас тэнгэр элчүүд ч хүмүүний

22a су Бурхан, Бурхан тэргүүтэн.
б Мосе 5:58.
су Тэнгэр элчүүд.
24a 2 Ниф. 2:5.
25a Алма 12:28–30.

26a 3 Ниф. 18:20.
су Залбирал.
27a Иса. 53:12;
Мозая 14:12.
б су Гайхамшиг.
28a Ром 12:9;

С ба Г 98:11.
б 1 Иохан 2:1;
2 Ниф. 2:9.
су Өмгөөлөгч.

үрсэд тохинуулахаа больсон нь үгүй.

30 Учир нь болгоогтун, хүчит итгэлтэй мөн гуйвшгүй бодолтой тэдэнд бурханлгй чанар бүрээр өөрсдийгөө үзүүлэхээр, түүний зарлигийн үгийн дагуу тохинуулахаар тэд түүнд харьяалагддаг.

31 Мөн хүмүүнийг наманчлалд дуудах нь, мөн хүмүүний үрстэй түүний хийсэн, Эцэгийн гэрээнүүдийн ажлыг хийж мөн гүйцэлдүүлэх нь, тэд нь түүний тухай гэрчлэлийг хуваалцаж болохын тулд Христийн үгийг Их Эзэний сонгогдсон савнуудад тунхагласнаар хүмүүний үрсийн дундах замыг бэлтгэх нь тэдний тохинууллын алба юм.

32 Мөн ийн хийснээр, үлдсэн бусад хүмүүс Ариун Сүнсний хүчнийхээ дагуу тэдний зүрх сэтгэлд байр олж болох Христэд “итгэлтэй байж болох замыг Их Эзэн Бурхан бэлтгэдэг; мөн энэ маягаар Эцэг, хүмүүний үрстэй хийсэн өөрийн гэрээнүүдийг улируулан тохиолгодог.

33 Мөн Христ хэлдэг: “Хэрэв та нар надад итгэлтэй байх аваас та нар миний хувьд ^бшаардлагатай болох аливаа зүйлийг хийх хүчтэй байх болно.

34 Мөн тэрбээр: Газар дэлхийн хязгаарууд та нар бүгд аврагдаж болохын тулд

“наманчлагтун, мөн надад ирж, мөн миний нэрээр баптисм хүртэгтүн, мөн та нар надад итгэлтэй байгтун хэмээн хэлдэг.

35 Мөн эдүгээ, хайрт ах дүүс минь, хэрэв та нарт миний ярьсан эдгээр зүйлс үнэн байх аваас, мөн тэдгээр нь үнэнийг Бурхан эцсийн “өдөр ^бхүчтэйгээр мөн агуу алдар суугаар та нарт үзүүлэх болно, мөн хэрэв тэдгээр нь үнэн байхад гайхамшгуудын өдөр байхаа больсон гэж үү?

36 Эсвээс тэнгэр элчүүд хүмүүний үрсэд үзэгдэхээ больсон гэж үү? Эсвээс тэрбээр Ариун Сүнсний хүчийг тэднээс “далдалсан гэж үү? Эсвээс тэр, цаг хугацаа үргэлжлэн байхад, эсвээс газар дэлхий оршсоор байхад, эсвээс үүний гадаргуу дээр аврагдаж болох ганцхан боловч хүн байхад тэгэх гэж үү?

37 Болгоогтун би та нарт хэлнэ, Үгүй; учир нь “гайхамшгууд үйлдэгдэх нь итгэлээр бөлгөө; мөн хүмүүнд тэнгэр элчүүд үзэгдэж мөн тохинуулах нь итгэлээр юм; иймийн тул, хэрэв эдгээр зүйл байхаа больсон бол хүмүүний үрсэд халаг болог, учир нь энэ бол ^битгэлгүйн учир, тиймийн тул бүгд хоосон юм.

38 Учир нь Христийн үгсийн дагуу түүний нэрэнд итгэлтэй байхгүй бол ямар ч хүн

32a су Итгэл.

33a Мат. 17:20.

б С ба Г 88:64–65.

34a з Ниф. 27:20;

Ифер 4:18.

35a С ба Г 35:8.

б 2 Ниф. 33:11.

36a Моро. 10:4–5, 7, 19.

37a Мат. 13:58;

Морм. 9:20;

Ифер 12:12–18.

б Моро. 10:19–24.

аврагдаж чадахгүй; иймийн тул, хэрэв эдгээр зүйлс байхаа больсон гэвэл, тэгвэл итгэл ч түүнчлэн үгүй болсон гэсэн үг; мөн хүмүүний байдал аймшигтай байна, учир нь тэд гэтэлгэл хийгдээгүй мэт байх болно.

39 Гэвч болгоогтун, хайрт ах дүүс минь, би та нарын талаар илүү сайн дүгнэлтэд хүрэв, учир нь хүлцэнгүй номхон байдлын тань учир Христэд итгэх итгэл та нарт байгаа хэмээх дүгнэлтэнд би хүрэв; учир нь хэрэв та нар түүнд итгэлгүй байвал, тэгвэл та нар түүний сүмийн хүмүүсийн дунд тоологдох нь “тохиромжгүй билээ.

40 Мөн тэрчлэн, хайрт ах дүүс минь, би та нарт “найдарын талаар ярьмаар байна. Та нар найдваргүйгээр, яахан итгэлийг олж чадах билээ?

41 Мөн та нар юуны төлөө “найдах билээ? Болгоогтун та нар Христийн цагаатгал, мөн түүний амилалтын хүчээр, ^бмөнх амьдралд босгогдохын тулд “найдахыг би та нарт хэлье, мөн энэ нь амлалтын дагуу түүнд итгэлтэйн тань учир болой.

42 Иймийн тул, хүмүүн “итгэлтэй аваас түүнд найдвар байх нь ^бгарцаагүй; учир нь

итгэлгүйгээр ямар ч найдвар байж чадахгүй.

43 Мөн тэрчлэн, болгоогтун тэр “хүлцэнгүй даруу, мөн зүрх сэтгэлдээ номхон байхгүй аваас, түүнд итгэл хийгээд найдвар байх аргагүйг би та нарт хэлнэ.

44 Хэрэв тийм аваас, түүний “итгэл хийгээд найдвар нь хоосон, учир нь хүлцэнгүй даруу мөн зүрх сэтгэлдээ номхон байхаас бусдаар, хэн ч Бурханы өмнө хүлээн зөвшөөрөгдөхүйц байхгүй; мөн хэрэв хүмүүн хүлцэнгүй даруу мөн зүрх сэтгэлдээ номхон, мөн Ариун Сүнсний хүчээр Есүс бол Христ гэдгийг хүлээн ^бзөвшөөрдөг аваас, түүнд энэрэл байх нь гарцаагүй; учир нь түүнд энэрэл үгүй бол тэр хэн ч биш билээ; иймийн тул түүнд энэрэл байх нь гарцаагүй.

45 Мөн “энэрэл бол удаан гэсвэрлэдэг, мөн сайхан сэтгэлтэй, мөн ^батаархаж жөтөөрхөх нь үгүй, мөн онгирч хөөрдөггүй, өөрийнхийгөө эрэлхийлдэггүй, амар өдөөн хатгагддаггүй, ямар ч хилэнцтийг боддоггүй, мөн алдаст баясах нь үгүй, харин үнэнд баясдаг, бүх зүйлийг хүлцдэг, бүх зүйлд итгэдэг, бүх зүйлд найддаг, бүх зүйлийг тэвчдэг.

46 Иймийн тул, хайрт ах

39а су Зөв зохистой, Зөв зохистой байдал.

40а Ифер 12:4. су Найдвар.

41а С ба Г 138:14.

б су Мөнх амьдрал. в Тит. 1:2; Иаков 4:4;

Алма 25:16; Моро. 9:25.

42а су Итгэл.

б Моро. 10:20.

43а су Номхон дөлгөөн, Номхон дөлгөөн байдал.

44а Алма 7:24;

Ифер 12:28–34.

б Лук 12:8–9.

су Хүлээн зөвшөөрөх, Хүлээн зөвшөөрөлт; Гэрчлэл.

45а 1 Кор. 13:1–13.

б су Атаархал.

дүүс минь, хэрэв та нарт энэрэл үгүй бол, та нар хэн ч биш, учир нь энэрэл хэзээ ч дуусдаггүй; иймийн тул, бүхнээс илүү агуу тэрхүү энэрлээс зууран барь, учир нь бүх зүйл дуусах ёстой —

47 Гэвч “энэрэл бол Христийн цэвэр ^бхайр, мөн энэ нь үүрд үл цөхрөх ажгуу; мөн эцсийн өдөр үүнийг эзэмшиж байгаа хэнд боловч, түүнд сайн байх болно.

48 Иймийн тул, хайрт ах дүүс минь, та нар түүний Хүү, Есүс Христийн үнэн “дагалдагчид бүгдийн дээр түүний цутгасан хайраар дүүргэгдэж болохын төлөө; та нар Бурханы хөвгүүд болж болохын тулд; тэрбээр хүрч ирэхэд бид түүнтэй ^бадил байх болно, учир нь бид түүнийг байгаагаар нь харах болно гэсний учир, бидэнд энэ найдвар байж болохын тулд, түүний цэврийн адил бид ^бцэвэр болгогдож болохын тулд зүрхнийхээ бүхий л эрч хүчээр Эцэгт хандан залбирагтун. Амен.

БҮЛЭГ 8

Бага насны хүүхдүүдийн баптисм бол хилэнцэт жигшүүрт үйл — Цагаатгалын улмаас бага

насны хүүхдүүд Христээр амьд — Итгэл, наманчлал, даруу байдал, мөн зүрх сэтгэлийн номхон хүлээнгүй чанар, Ариун Сүнсийг хүлээн авч, мөн эцсээ хүртэл тэвчих нь авралд хүргэдэг. Ойролцоогоор мэ 401–421 он.

Миний “эцэг Мормоны, Моронай надад бичиглэсэн захидал оршвой; мөн энэ нь намайг тохинуулалд дуудагдсанаас хойш удалгүй надад бичигдсэн юм. Мөн ийм байдлаар тэрээр надад бичсэн билээ, өгүүлсэн нь:

2 Моронай, хайрт хүү минь, Их Эзэн Есүс Христ чинь чамд анхааран хандсан билээ, мөн өөрийн тохинуулалд, мөн ариун ажилдаа чамайг дуудсанд би үлэмж баяснам.

3 Тэрбээр өөрийн хэмжээлшгүй “сайн сайхан мөн ^бач ивээлээр өөрийнх нь нэрэнд итгэх итгэлийн эцсийг хүртэлх тэвчээрээр чамайг хадгалаасай хэмээн, Бурхан Эцэгт түүний Ариун Хүүхэд, Есүсийн нэрээр би үргэлж залбиран, чамайг залбиралдаа үргэлж анхаардаг билээ.

4 Мөн эдүгээ, миний хүү, намайг үлэмж гонсойлгож буй түүний талаар би чамд ярья; учир нь та нарын дунд “арцалдаанууд гардаг нь намайг гонсойлгож байна.

5 Учир нь, хэрэв би үнэнийг

47a 2 Ниф. 26:30.

су Энэрэл.

б Иош. 22:5.

су Хайр.

48a су Есүс Христ—

Есүс Христийн

үлгэр жишээ;

Дуулгавартай байх,

Дуулгавартай,

Дуулгавартай дагах.

б 1 Иохан 3:1–3;

3 Ниф. 27:27.

в 3 Ниф. 19:28–29.

су Цэвэр ариун,

Цэвэр ариун байдал.

г су Залбирал.

8 1a Мор. үгс 1:1.

3a Мозая 4:11.

б су Ач ивээл.

4a 3 Ниф. 11:22, 28;

18:34.

мэдсэн аваас, бага насны хүүхдүүдийн тань баптисмын талаар та нарын дунд арцалдаан байгаа юм.

6 Мөн эдүгээ, хүү минь, та нарын дундаас энэхүү ноцтой алдаа зайлуулагдахын тулд, чамайг хичээнгүйлэн хөдөлмөрлөөсэй хэмээн хүснэ би; учир нь, энэхүү зорилгын улмаас би энэ захидлыг бичиж байна.

7 Учир нь та нарын талаар эдгээр зүйлсийг би мэдэнгүүтээ л энэ хэргийн талаар Их Эзэнээс лавлалаа. Мөн Ариун Сүнсний хүчээр Их Эзэний “үг надад ирж, хэлсэн нь:

8 Өөрийн гэтэлгэгч, өөрийн Их Эзэн, мөн өөрийн Бурхан Христийн үгсийг сонс. Болгоогтун, би дэлхийд зөв шударгыг үйлдэгчдийг бус, нүгэлтнүүдийг наманчлалд дуудахаар ирсэн билээ; “эрүүлд эмчийн хэрэгцээ үгүй, харин өвчтэй тэдэнд; иймийн тул, бага насны ^бхүүхдүүд ^вэрүүл, учир нь тэд ^гнүгэл үйлдэх чадваргүй юм; иймийн тул ^дАдамын зүхэл, тэр нь тэдний дээр хүчгүй байхаар, тэднээс надаар зайлуулагдсан болой; мөн ^ехөвч хөндөх хууль надаар эцэс болсон юм.

9 Мөн энэ байдлаар Бурханы үгийг Ариун Сүнс надад мэдүүлсэн буюу; иймийн тул, хайрт хүү минь, та нар бага насны хүүхдүүдэд баптисм хүртээх нь Бурханы өмнөх сүрхий элэглэл болохыг би мэднэ.

10 Болгоогтун энэ зүйлийг та нар заах болно гэдгийг би чамд хэлье — “хариуцлага хүлээх мөн нүгэл үйлдэх чадвартай тэдэнд наманчлал мөн баптисмыг; тийм ээ, тэд наманчилж мөн баптисм хүртэн, мөн бага насны ^бхүүхдүүдийнхээ адил өөрсдийгөө даруухан болгох ёстой, тэгвэл тэд бүгдээр бага насны хүүхдүүдийнхээ хамт аврагдах болно гэдгийг эцэг эхчүүдэд заагтун.

11 Мөн тэдний бага насны “хүүхдүүдэд наманчлал ч, бас баптисм ч огт хэрэггүй болой. Болгоогтун, нүглийн ^бангижралыг авах зарлигуудыг биелүүлэхийн тулд баптисм нь наманчлалд хүргэдэг.

12 Гэвч бага насны “хүүхдүүд бүр дэлхийн үүслээс Христээр амьд; хэрэв тийм бус аваас, Бурхан нь ялгаварладаг Бурхан, мөн түүнчлэн хувирамтгай Бурхан, мөн ^бнүүр тал харагч болно; учир нь

7а су Бурханы Үг.

8а Марк 2:17.

б Марк 10:13–16.

в Мозая 3:16;

С ба Г 74:7.

г су Нүгэл.

д 2 Ниф. 2:25–27.

су Адам Ева хоёрын

Уналт.

е Эхл. 17:10–11.

су Хөвч хөндөх ёслол.

10а су Хариуцах, Хариуцлага, Хариуцлагатай.

б су Хүүхэд, Хүүхдүүд; Даруу, Даруу байдал.

11а су Баптисм, Баптисм хүртээх—

Баптисмд тэнцэх; Хүүхэд, Хүүхдүүд.

б су Нүглүүдийн ангижрал.

12а С ба Г 29:46–47; 93:38.

б Ефес 6:9;

2 Ниф. 26:33;

С ба Г 38:16.

хичнээн олон бага насны хүүхдүүд баптисмгүйгээр нас нөгчсөн билээ!

13 Иймийн тул, хэрэв бага насны хүүхдүүд баптисмгүйгээр аврагдаж чадахгүй аваас, тэд эцэсгүй тамд одсон байх нь гарцаагүй.

14 Болгоогтун би та нарт хэлнэ, бага насны хүүхдүүдэд баптисм хэрэгтэй хэмээн боддог тэр нь гашуудлын гүнд мөн алдсын хүлээст байгаа буюу; учир нь түүнд “итгэл, найдвар, мөн энэрэл ч үгүй болой; иймийн тул, тэрбээр уг бодолдоо өнгөрвөөс, тэрбээр там уруу явах нь гарцаагүй болой.

15 Учир нь Бурхан баптисмаар нэг хүүхдийг аврахад, мөн нөгөө нь баптисмгүйн тулд эрсдэх ёстой хэмээн бодохын ёс бус нь аймшигтай юм.

16 Энэ байдлаар Их Эзэний замуудыг гажуудуулдаг тэдэнд халаг, учир нь тэд наманчлахгүй аваас тэд мөхөх болно. Болгоогтун, би Бурханы “эрх мэдэлтэй учир зоригтойгоор ярьж байна; мөн би хүмүүний юу хийж чадахаас үл айна; учир нь төгс ^бхайр бүх айдсыг “зайлуулдаг.

17 Мөн би үүрдийн хайр

болох “энэрлээр дүүргэгдсэн; иймийн тул, бүх хүүхдүүд миний хувьд адил юм; иймийн тул, би бага насны ^бхүүхдүүдийг төгс хайраар хайрладаг; мөн тэд бүгдээр адилхан мөн авралыг хүртэгсэд бөлгөө.

18 Учир нь Бурхан бол ялгаварлагч Бурхан биш, мөн өөрчлөгдөгч нэгэн бишийг; харин тэрбээр “бүх үүрд мөнхөөс бүх үүрд мөнхөд ^бөөрчлөгдөшгүйг би мэднэ.

19 Бага насны “хүүхдүүд наманчилж чадахгүй; иймийн тул, тэдэнд Бурханы хандуулсан цэвэр ариун нигүүлслийг үгүйсгэх нь аймшигт ёс бус явдал мөн, учир нь түүний ^бнигүүлслийн улмаас тэд бүгд түүгээр амьд юм.

20 Мөн бага насны хүүхдүүдэд баптисм хэрэгтэй хэмээн хэлэх тэр нь Христийн нигүүлслийг үгүйсгэж, мөн түүний “цагаатгал хийгээд түүний гэтэлгэлийн хүчийг юу ч бус хэмээн үнэлж буй хэрэг.

21 Тэдэнд халаг, учир нь тэд “тамын, үхлийн, мөн ^бтөгсгөлгүй тарчлалын аюулд байна. Би үүнийг зоригтойгоор хэлнэ; Бурхан надад зарлиг болгосон юм. Тэднийг сонс мөн анхаарал тавь, эсвээс тэд

14a 1 Кор. 13:1–13;
Ифер 12:6;
Моро. 7:25–28;
10:20–23.

16a су Эрх мэдэл.
б су Хайр.
в 1 Иохан 4:18.

17a су Энэрэл.
б Мозая 3:16–19.

18a Моро. 7:22.
б Алма 7:20;
Морм. 9:9.
су Бурхан, Бурхан
тэргүүтэн.

19a Лук 18:15–17.
б су Нигүүлсэнгүй,
Нигүүлсэл.

20a су Цагаатгах,

Цагаатгал;
Гэтэлгэлийн
төлөвлөгөө.
21a су Там.
б Иаков 6:10;
Мозая 28:3;
С ба Г 19:10–12.

Христийн “шүүлтийн суудлын дэргэд та нарын эсрэг зогсох болно.

22 Учир нь болгоогтун бүх бага насны хүүхдүүд, мөн түүнчлэн “хуульгүй орших тэд бүгд Христээр ^бамьд юм. Учир нь ^ггэтэлгэлийн хүч хуульгүй тэд бүгдэд ирдэг; иймийн тул, буруутгагдаагүй тэр нь, өөрөөр хэлбэл буруутгал дор эс орших тэр нь, наманчилж чадахгүй; мөн тийм нэгэнд баптисм ямар ч тусгүй юм —

23 Гэвч Христийн нигүүлслийг, мөн Ариун Сүнсний хүчийг үгүйсгэж, мөн “үхмэл үйлд итгэлээ тавих нь Бурханы өмнөх элэглэл юм.

24 Болгоогтун, хүү минь, энэ зүйл байх учиргүй; учир нь “наманчлал нь буруутгал дор буй мөн зөрчигдсөн хуулийн зүхэл дор буй тэдний төлөө юм.

25 Мөн “наманчлалын анхны үр жимс бол ^ббаптисм юм; мөн итгэлээр ирдэг баптисм зарлигуудыг биелүүлэхэд хүргэдэг; мөн зарлигуудыг биелүүлэх нь нүглийн ^бангижралыг авчирдаг;

26 Мөн нүглийн ангижрал

нь “даруу байдал мөн зүрх сэтгэлийн хүлцэнгүй чанарыг авчирдаг; мөн даруу байдал хийгээд зүрх сэтгэлийн хүлцэнгүй чанарын улмаас, ^бнайдвар хийгээд төгс “хайраар дүүргэх ^гТайтгаруулагч болох ^дАриун Сүнсний айлчлал нь ирдэг, ^езалбирал дахь ^жхичээл зүтгэлийн учир бүх ^згэгээнтнүүд Бурхантай хамт орших эцсийг ирэх хүртэл тэрхүү хайр үл цөхрөх болно.

27 Болгоогтун, хүү минь, хэрэв ойрын үед би леменчүүдийн эсрэг явахгүй бол, би чамд дахин бичих болно. Болгоогтун, энэ үндэстний, өөрөөр хэлбэл нифайчуудын хүмүүсийн “бардамнал, тэд наманчлахгүй аваас тэднийг устгалд хүргэсээр байна.

28 Тэдэнд наманчлал ирээсэй хэмээн, тэдний төлөө залбир, хүү минь. Гэвч болгоогтун, Сүнс тэдний төлөө “зүтгэхээ больсон болов уу хэмээн айна би; мөн уг нутгийн энэ хэсэгт тэд түүнчлэн Бурханаас ирэх бүх хүч хийгээд эрх мэдлийг түлхэн унагахаар эрэлхийлж байна; мөн тэд Ариун Сүнсийг ^бүгүйсгэж байна.

21*в* су Есүс Христ— Шүүгч.

22*а* Үйлс 17:30;
С ба Г 76:71–72.

б су Аврал— Хүүхдүүдийн аврал.

в су Гэтэлгэх, Гэтэлгэгдэх, Гэтэлгэл.

23*а* С ба Г 22:2.

24*а* су Наманчлах, Наманчлал.

25*а* су Баптисм, Баптисм хүртээх— Баптисмд тэнцэх.

б Мосе 6:58–60.

в С ба Г 76:52.
су Нүглүүдийн ангижрал.

26*а* су Номхон дөлгөөн, Номхон дөлгөөн байдал.

б су Найдвар.

в 1 Петр 1:22;
1 Ниф. 11:22–25.

г су Тайтгаруулагч.

д су Ариун Сүнс.

е су Залбирал.

ж су Хичээл зүтгэл.

жсу Гэгээнтэн.

27*а* С ба Г 38:39.

су Бардамнал.

28*а* Морм. 5:16.

б Алма 39:6.
су Уучлагдашгүй нүгэл.

29 Мөн ийм агуу нэгэн мэдлэгийг эсэргүүцсэний дараа, хүү минь, бошиглогчдоор хэлэгдсэн бошиглолыг, мөн түүнчлэн бидний Аврагчийн өөрийнх нь үгсийг гүйцэлдүүлэхийн тулд тэд удахгүй мөхөх ёстой.

30 Сайныг ерөөе, хүү минь, би чамд дахин бичих хүртэл, эсвээс чамтай дахин уулзах хүртэл. Амен.

Хүү Моронайдаа илгээсэн Мормоны хоёр дахь захидал оршвой.

9 дүгээр бүлэгт агуулагдав.

БҮЛЭГ 9

Нифайчууд мөн леменчүүд аль аль нь завхарч мөн доройтов— Тэд бие биенээ тамлан мөн хөнөөж байв— Моронай дээр ач ивээл мөн сайн сайхан үүрд тогтоосой хэмээн Мормон залбирав. Ойролцоогоор мэ 401–421 он.

Хайрт хүү минь, би амьд хэвээр гэдгийг чи мэдэж болохын тулд би чамд дахин бичиж байна; гэвч би эмгэнэлт болох тэрний талаар заримыг бичье.

2 Учир нь болгоогтун, бид ялж чадаагүй тэрхүү, ширүүн тулалдаанд би леменчүүдтэй орсон; мөн Аркаинтас, мөн түүнчлэн Лурам мөн Эмрон илдээр унагагдсан болой;

тийм ээ, мөн бид сонгомол эрсээсээ агуу олон тоотойг алдсандаа.

3 Мөн эдүгээ болгоогтун, хүү минь, леменчүүд энэ хүмүүсийг устгах вий хэмээн айна би; учир нь тэд наманчилдаггүй, мөн Сатан тэднийг үргэлж нэг нэгэнтэй нь уур хилэнд өдөөн хатгадаг.

4 Болгоогтун, би тэдэнтэй үргэлж хөдөлмөрлөж байна; мөн би Бурханы үгийг “хурцаар хэлэхэд тэд дагжин мөн миний эсрэг хилэгнэдэг; мөн би хурцаар эс ярихад тэд түүний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулдаг; иймийн тул, Их Эзэний Сүнс тэдний төлөө ⁶зүтгэхээ больсон болов уу хэмээн айна би.

5 Учир нь тэд үхлээс үл эмээх мэт надад санагдахаар тэд тийн үлэмж ихээр хилэгнэдэг; мөн тэд нэг нэгэндээ хандах хайраа гэсэн байна; мөн тэд цусанд мөн өшөө авахад үргэлжлэн “шунадаг.

6 Мөн эдүгээ, хайрт хүү минь, тэд хатуурсан гэлээ ч, “хичээнгүйгээр хөдөлмөрлөцгөөе; учир нь хэрэв бид ⁶хөдөлмөрлөхөө боливол, бид буруушаалтын дор аваачигдах болно; учир нь бид бүх зөв шударгын дайсныг ялж, мөн өөрсдийн бодгалийг Бурханы хаант улсад амрааж болохын тулд энэ махбодийн асарт байхдаа гүйцэтгэх хөдөлмөр бидэнд байна.

7 Мөн эдүгээ би энэ

9 4a 2 Ниф. 1:26–27;
С ба Г 121:41–43.
б С ба Г 1:33.

5a Морм. 4:11–12.
6a су Хичээл зүтгэл.
б Иаков 1:19;

Инос 1:20.
су Үүрэг.

хүмүүсийн зовлон зүдгүүрийн талаар заримыг бичье. Учир нь Амороноос хүлээн авсан миний мэдлэгийн дагуу, болгоогтун, тэд Шеризагийн цамхагаас авсан олон хоригдол леменчүүдэд бий; мөн эрчүүд, эмэгтэйчүүд, мөн хүүхдүүд ч бий.

8 Мөн тэдгээр эмэгтэйчүүдийн нөхрүүд мөн хүүхдүүдийн эцгийг нь тэд хөнөөсөн; мөн тэд эмэгтэйчүүдийг өөрсдийнх нь нөхрүүдийн цогцсоор, мөн хүүхдүүдийг өөрсдийнх нь эцгүүдийн цогцсоор тэжээдэг; мөн багыг эс тооцвол, тэд тэдэнд ус өгдөггүй.

9 Мөн леменчүүдийн энэхүү агуу жигшүүрт хэрэг байгаа хэдий ч, энэ нь Мориантум дахь бидний хүмүүсийнхээс давж гараагүй юм. Учир нь болгоогтун, леменчүүдийн охидын олныг тэд олзлон авсан бөлгөө; мөн бүхнээс илүү хамгийн эрхэм мөн үнэтэй, “ариун явдал хийгээд” онгон байдлаас нь тэднийг салгасны дараа —

10 Мөн тэд энэ зүйлийг хийсний дараа, тэд биеийг нь бүр үхэлд хүртэл нь тамлан, хамгийн хэрцгий балмадаар хөнөөсөн билээ; мөн тэд үүнийг хийснийхээ дараа, зүрх сэтгэлийнхээ хатуугийн улмаас, тэд цогцсыг нь зэрлэг араатнууд лугаа адил цөлмөн идсэн гээч; мөн тэд үүнийг эр зоригийн тэмдэг болгон хийсэн аж.

11 Ай хайрт хүү минь, иргэншилгүй ийм хүмүүс хэрхэн —

12 (Мөн тэд соёлтой мөн бахдам сайхан хүмүүс байсан үеэс зөвхөн цөөн хэдэн жил улирч одсон буюу)

13 Гэвч Ай хүү минь, баясал нь ийм нэтэд их жигшүүрт хэрэгт байдаг ийм хүмүүс хэрхэн —

14 Бурхан бидний эсрэг шүүлтэнд өөрийн мутрыг “үл хөдөлгөнө хэмээн бид хэрхэн бодож чадах билээ?

15 Болгоогтун, зүрх сэтгэл минь дуу алднам: Энэ хүмүүст халаг. Шүүлтэнд гарч ирээч, Ай Бурхан минь, мөн тэдний нүглүүдийг, мөн ёс бусыг, мөн жигшүүрт хэргүүдийг нүүрнээсээ далдлаач!

16 Мөн түүнчлэн, хүү минь, Шеризад үлдсэн олон “бэлэвсэн эмэгтэйчүүд мөн тэдний охид буй; мөн леменчүүдийн авч одоогүй хоол хүнсний тэр хэсгийг, болгоогтун, Зенефайн их цэрэг авч одсон бөлгөө, мөн хүнсний тулд боломжтой газруудаар тэнүүчлүүлэхээр тэднийг орхисон ажээ; мөн настай олон эмэгтэйчүүд замдаа сульдан мөн үхэж байна.

17 Мөн надтай буй их цэрэг сул дорой; мөн леменчүүдийн их цэрэг Шериза болон миний дунд буй; мөн “Аароны их цэрэгт зугтан очсон болгон, тэд тэдний аймшигт харгислалын золиос болон унасан билээ.

18 Ай миний хүмүүсийн

9а су Ариун явдал.
б су Нөлөөлөх хүч.

14а Алма 10:23.
16а су Бэлэвсэн.

17а Морм. 2:9.

завхрал! Тэдэнд эмх цэгц хийгээд нигүүлсэл гэж үгүй болжээ. Болгоогтун, би энгийн хүмүүн, мөн би энгийн хүмүүний хүч тэнхээтэй, мөн би өөрийн зарлигуудыг цаашид тулгаж чадахгүй.

19 Мөн тэд тэрс байдалдаа хүчирхэг болж; мөн тэд залуу хөгшин хэнийг ч үл хэлтрүүлэгч харгис хэрцгий болжээ; мөн тэд сайн болох тэрнээс өөр бусад бүх зүйлд баясдаг; мөн энэ нутгийн бүх гадаргуу дээрх бидний эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийн зовлон юунаас ч давж гарна; тийм ээ, хэл үүнийг хэлж үл чадна, мөн энэ нь бичигдэж эс чадна.

20 Мөн эдүгээ, хүү минь, энэ аймшигт дүр зургийг би үргэлжлүүлэн бичиж чадашгүй нь. Болгоогтун, энэ хүмүүсийн ёс бусыг чи мэднэ; тэд зарчимгүй, мөн мэдрэхээс өнгөрснийг чи мэднэ; мөн тэдний ёс бус нь леменчүүдийнхээс ч "илүү.

21 Болгоогтун, хүү минь, тэрбээр намайг цохих вий хэмээн би тэднийг Бурханд санал болгож чадахгүй байна.

22 Гэвч болгоогтун, хүү минь, би чамайг Бурханд санал болгоно, мөн чамайг аврагдана хэмээн Христэд би найддаг; мөн түүний хүмүүс өөрт нь буцахын, эсвээс тэдний бүрмөсөн устгалын гэрч

болгохоор амийг чинь "хэлтрүүлээсэй хэмээн би Бурханд залбирна; учир нь тэд^бнаманчилж мөн түүнд буцахгүй аваас тэд мөхөх ёстойг би мэднэ.

23 Мөн хэрэв тэд мөхөх аваас энэ нь, цус хийгээд өс хонзонг "эрэлхийлэгч, тэдний зүрх сэтгэлийн^бзөрүүдийн улмаас, жаредчуудын адил болох болно.

24 Мөн хэрэв тэд мөхөх аваас, бидний ах дүүсийн олон нь леменчүүдэд "урвасан, мөн илүү олон нь түүнчлэн тэдэнд урвах болно гэдгийг бид мэднэ; иймийн тул, хэрэв чи хэлтрүүлэгдэж мөн би мөхөн мөн чамайг эс харах аваас, зарим цөөн зүйлийг бичигтүн; гэвч би чамайг удахгүй харна хэмээн найдна; учир нь чамд^бөгөхийг хүссэн ариун нандин цэдгүүд надад буй.

25 Хүү минь, Христэд итгэлтэй бай; мөн миний бичсэн зүйлүүд чамайг үхэлд хүргэх болтол шаналгахгүй байгаасай; харин Христ чамайг өргөн, мөн түүний "зовлон хийгээд үхэл, мөн бидний өвөг дээдэст өөрийн биеийг үзүүлсэн нь, мөн түүний нигүүлсэл хийгээд тэвчээр, мөн түүний алдар суугийн мөн^бмөнх амьдралын найдвар "оюунд чинь үүрд байг.

26 Мөн хаан сэнтий нь тэнгэрийн өндөрт байх Бурхан

20а Хил. 6:34–35.

22а Морм. 8:3.

б Малах. 3:7;

Хил. 13:11;

3 Ниф. 10:6; 24:7.

23а Морм. 4:11–12.

б Ифер 15:15–31.

24а Алма 45:14.

б Морм. 6:6.

25а су Цагаатгах,

Цагаатгал.

б су Мөнх амьдрал.

в су Оюун.

Эцэгийн, мөн бүх зүйл түүнд харьяалагдах хүртэл түүний хүчний “баруун гар талд залрах бидний Их Эзэн Есүс Христийн ач ивээл чамтай байж, мөн үүрд мөнх хамт орших болтугай. Амен.

БҮЛЭГ 10

Мормоны Номын тухай гэрчлэл
Ариун Сүнсний хүчээр ирдэг —
Сүнсний бэлгүүд итгэлтнүүдэд өгөгддөг —
Сүнсний бэлгүүд итгэлийг үргэлж дагалддаг —
Моронайн үгс газар шорооноос ярих болно —
Христэд ирэгтүн, түүгээр төгөлдөржиж, мөн өөрсдийн бодгалийг ариусгагтун.
Ойролцоогоор мэ 421 он.

Эдүгээ би, Моронай, надад зөв санагдах заримыг бичье; мөн би өөрийн ахан дүүс, “леменчүүдэд бичнэ; мөн Христийн ирэлтийн тэмдэг өгөгдсөнөөс чанагш дөрвөн зуун хориос илүү жил улирч одсоныг тэд мэдээсэй хэмээн хүснэ би.

2 Мөн та нарт ухуулах замаар хэдэн үг хэлснийхээ дараа, би эдгээр цэдгийг “лацдах болно.

3 Болгоогтун, та нар эдгээр зүйлийг уншихдаа, хэрэв та

нар тэдгээрийг унших нь Бурханы мэргэн ухаанд нийцэх аваас, Адам бүтээгдсэнээс бүр та нар эдгээр зүйлийг хүлээн авах тэр цагийг хүртэл Их Эзэн хүмүүний үрсэд хичнээн нигүүлсэнгүй байсаар буйг та нар санан мөн үүнийг “зүрх сэтгэлдээ ^бтунгаахыг та нарт ухуульга би.

4 Мөн та нар эдгээр зүйлийг хүлээн аваад, та нар Бурхан, Мөнхийн Эцэгээс, Христийн нэрээр, эдгээр зүйлүүд үнэн “эсэхийг ^басуухыг та нарт ухуульга би; мөн хэрэв та нар Христэд ^гитгэлтэй байж, ^гчин сэтгэлтэйгээр, ^дүнэн хүсэлтэйгээр асуух аваас, тэрбээр үүний ^дүнэнийг Ариун Сүнсний хүчээр та нарт ^дмэдүүлэх болно.

5 Мөн Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн “үнэнийг ^дмэдэж болно.

6 Мөн сайн болох аливаа зүйл шударга бөгөөд үнэн; иймийн тул, сайн болох юу ч Христийг үгүйсгэдэггүй, харин түүний буйг хүлээн зөвшөөрдөг.

7 Мөн Ариун Сүнсний хүчээр, түүний буй гэдгийг та нар мэдэж болно; иймийн тул Бурханы хүчийг та нар үгүйсгэхгүй байхыг та нарт

26a Лук 22:69;
 Үйлс 7:55–56;
 Мозая 5:9;
 Алма 28:12.

10 1a С ба Г 10:48.

2a Морм. 8:4, 13–14.
 су Судрууд—Ирнэ хэмээн бошиглогдсон судрууд.

3a Дэд хууль 6:6–7.
 б Дэд хууль 11:18–19.
 су Тунгаан бодох.

4a 1 Ниф. 13:39; 14:30;
 Мозая 1:6;
 Ифер 4:10–11; 5:3.

б су Залбирал.
 в су Итгэл.
 г су Үнэнч, Үнэнч шударга.

д Иаков 1:5–7;
 Моро. 7:9.

е су Үнэн.

ё су Илчлэлт.

5a Иохан 8:32.

б С ба Г 35:19.
 су Ялган таних бэлэг; Гэрчлэл.

ухуулъя би; учир нь тэрбээр хүмүүний үрсийн “итгэлийн дагуу хүчээр үйлддэг, өнөөдөр мөн маргааш, мөн үүрд хэвээр бөлгөө.

8 Мөн тэрчлэн, ахан дүүс минь, Бурханы “бэлгүүдийг та нар үгүйсгэхгүй байхыг би та нарт ухуулж байна, учир нь тэдгээр нь олон; мөн тэдгээр нь нэг Бурханаас ирдэг. Мөн уг бэлгүүд хүртээгдэх өөр “өөр замууд буй; гэвч хаана ч мөн юунд ч үйлдэгч нэг л Бурхан байдаг; мөн тэдгээр нь хүмүүнд, тэдэнд тус болохын тулд, Бурханы Сүнсний нөлөөгөөр өгөгддөг.

9 Учир нь болгоогтун, “нэгэнд нь Бурханы Сүнсээр, тэрбээр мэргэн ухааны үгийг “зааж болох нь өгөгддөг;

10 Мөн өөр нэгэнд нь, тэрбээр мөнхүү Сүнсээр мэдлэгийн үгийг зааж болох нь;

11 Мөн өөр нэгэнд нь, үлэмж агуу “итгэл; мөн өөр нэгэнд, мөнхүү Сүнсээр “эдгээх бэлгүүд;

12 Мөн тэрчлэн, өөр нэгэнд нь, тэрбээр хүчит “гайхамшигуудыг үйлдэж болох нь;

13 Мөн тэрчлэн, өөр нэгэнд нь, тэрбээр бүх зүйлийн талаар бошиглож болох нь;

14 Мөн тэрчлэн, өөр нэгэнд нь, тэнгэр элчүүдийг мөн тохинуулах сүнснүүдийг болгоох нь;

15 Мөн тэрчлэн, өөр нэгэнд нь, бүх төрлийн хэл;

16 Мөн тэрчлэн, өөр нэгэнд нь, хэл ярианы мөн олон төрлийн “хэлнүүдийг хөрвүүлэх нь өгөгддөг.

17 Мөн эдгээр бүх бэлэг нь Христийн Сүнсээр ирдэг; мөн тэдгээр нь түүний тааллын дагуу, хүмүүн бүрд тус бүрчлэн ирдэг.

18 Мөн хайрт ахан дүүс минь, “сайн бэлэг болгон Христээс ирдгийг та нар санахыг та нарт ухуулъя би.

19 Мөн хайрт ахан дүүс минь, тэрбээр өчигдөр, өнөөдөр, мөн үүрд “адил гэдгийг, мөн миний ярьсан, сүнснийх болох эдгээр бүх бэлэг хэзээ ч, бүр дэлхий орших бүх хугацаанд алга болохгүй, хэрэв тэгвэл зөвхөн хүмүүний үрсийн “итгэлгүйн улмаас л гэдгийг санахыг та нарт ухуулъя би.

20 Иймийн тул, “итгэл байх учиртай; мөн хэрэв итгэл байх ёстой аваас түүнчлэн найдвар байх учиртай; мөн хэрэв найдвар байх ёстой аваас түүнчлэн энэрэл байх учиртай.

21 Мөн та нар “энэрэлтэй байхгүй аваас Бурханы хаант улсад та нар явч аврагдаж чадахгүй; бас хэрэв та нар итгэлгүй аваас Бурханы хаант улсад аврагдаж чадахгүй; мөн

7а 1 Ниф. 10:17–19.

8а су Сүнсний бэлгүүд.

б С ба Г 46:15.

9а 1 Кор. 12:8–11;

С ба Г 46:8–29.

б С ба Г 88:77–79, 118.

11а су Итгэл.

б су Эдгээх, Эдгэрэх.

12а су Гайхамшиг.

16а су Хэлний бэлгүүд.

18а Иаков 1:17.

19а Евр. 13:8.

б Моро. 7:37.

20а Ифер 12:3–37.

21а 1 Кор. 13:1–13;

Моро. 7:1, 42–48.

су Энэрэл.

хэрэв та нар найдвар үгүй аваас мөн чадахгүй.

22 Мөн хэрэв та нар найдвар үгүй аваас шантрах нь гарцаагүй; мөн шантрал алдсын улмаас ирдэг.

23 Мөн Христ бидний өвөг дээдэст үнэхээр хэлсэн юм: “Хэрэв та нарт итгэл байх аваас та нар миний хувьд зохистой болох аливаа зүйлийг хийж чадна.

24 Мөн эдүгээ би дэлхийн бүх хязгааруудад хэлж байна—хэрэв Бурханы хүч мөн бэлгүүд та нарын дундаас алга болох тэр өдөр ирэх аваас, энэ нь “итгэлгүйн” улмаас байх болно.

25 Мөн хэрэв нөхцөл нь ийм байх ахул хүмүүсийн үрсэд халаг болог; учир нь та нарын дунд сайныг хийгч “үгүй, үгүй, нэг ч үгүй. Учир нь хэрэв та нарын дунд сайныг үйлдэгч нэгэн байх ахул, тэрбээр Бурханы хүч хийгээд бэлгүүдээр ажиллах болно.

26 Мөн эдгээр зүйлсийг үгүй хийж мөн нас нөгчих тэдэнд халаг, учир нь тэд “нүглүүддээ нас” нөгчинө, мөн тэд Бурханы хаант улсад аврагдаж эс чадах бөлгөө; мөн Христийн үгсийн дагуу би үүнийг ярьж байна; мөн би худал хэлэх нь үгүй.

27 Мөн эдгээр зүйлсийг санахыг би та нарт ухуулж байна; учир нь миний худал эс хэлэхийг та нар мэдэх тэр цаг хурдтайгаар ирж байна, учир нь та нар намайг Бурханы тавцан дээр харах болно; мөн Их Эзэн Бурхан та нарт хэлнэ: Нас барагсдын дундаас “хашгирах нэгэн мэтээр, тийм ээ, бүр” газар шорооноос ярих нэгэн мэтээр, энэ хүнээр бичигдсэн өөрийн “үгсийг би та нарт тунхаглаагүй гэж үү?

28 Бошиглолуудыг гүйцэлдүүлэхээр би эдгээр зүйлүүдийг тунхаглаж байна. Мөн болгоогтун, эдгээр нь үүрдийн Бурханы амнаас гарах болно; мөн түүний үг үеэс үед “исгэрэн тархах болно.

29 Мөн миний бичсэн энэ нь үүнийг үнэнийг Бурхан та нарт үзүүлэх болно.

30 Мөн та нар Христэд “ирж, мөн сайн бэлэг болгоноос барьж аван, мөн хилэнцэт бэлэгт, бас цэвэр бус зүйлд үл” хүрэхийг та нарт ухуулъя би.

31 Мөн “сэрэгтүн, мөн шорооноос өндийгтүн, Ай Иерусалим; тийм ээ, мөн үзэсгэлэнт өмсгөлөө өмс, Ай” Сионы охин; мөн та нар “цаашид үл бусниулагдахын тул, Мөнхийн Эцэгийн Ай

23a Моро. 7:33.

24a су Итгэлгүй байдал.

б Моро. 7:37.

25a исо, Дуул. 14:1–7;

Ром 3:10–12.

26a Иохан 8:21.

б Езек. 18:26–27;

1 Ниф. 15:32–33;

Мозая 15:26.

27a 2 Ниф. 3:19–20;

27:13; 33:13;

Морм. 9:30.

б Иса. 29:4.

в 2 Ниф. 33:10–11.

28a 2 Ниф. 29:2.

30a 1 Ниф. 6:4;

Морм. 9:27;

Ифер 5:5.

б Алма 5:57.

31a Иса. 52:1–2.

б су Сион.

в Ифер 13:8.

Израилын угсаа, та нартай хийсэн гэрээнүүд биелэгдэж болохын тулд, үүрд ¹гадсаа ²бөхөлж мөн хилээ тэлэгтүн.

32 Тийм ээ, Христэд ³ирэгтүн, мөн түүгээр ⁴төгөлдөржигтүн, мөн бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзагтун; мөн хэрэв та нар бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзаж, мөн Бурханыг өөрсдийн бүх хүч, оюун, мөн чадлаар ⁵хайрлах аваас, тэгвэл түүний ач ивээл та нарт хангалттайгаас түүний ач ивээлээр та нар Христээр төгс байж болно; мөн хэрэв Бурханы ⁶ач ивээлээр та нар Христээр төгс аваас, та нар Бурханы хүчийг яв ч үгүйсгэж чадахгүй.

33 Мөн тэрчлэн, хэрэв Бурханы ач ивээлээр та нар

Христээр төгс, мөн түүний хүчийг эс үгүйсгэх аваас, тэгвэл Бурханы ач ивээлээр та нар Христээр, өөрсдийг тань нүглийн ⁷ангиралд хүргэх, Эцэгийн гэрээн дэх Христийн ⁸цусны урсалтаар ⁹ариусгагдсан билээ, тиймээс та нар ¹⁰ариун, толбогүй болно.

34 Мөн эдүгээ би бүгдэд сайныг ерөөе. Миний ¹¹сүнс болон махбодь ¹²дахин нэгдэж, мөн амьд үхсэний аль алиных нь Мөнхийн ¹³Шүүгч, агуу ¹⁴Иеховагийн ¹⁵таалалт тавцангийн өмнө та нартай уулзахаар би ¹⁶агаараар ялгуусан байдалтайгаар хүргэгдэх хүртэл, Бурханы ¹⁷диваажинд ¹⁸амрахаар удахгүй явах болно би. Амен.

31г су Гадас.

д Иса. 54:2.

32а Мат. 11:28;

2 Ниф. 26:33;

Иаков 1:7;

Омнай 1:26.

б Мат. 5:48;

3 Ниф. 12:48.

су Төгс.

в С ба Г 4:2; 59:5–6.

г 2 Ниф. 25:23.

33а су Нүглүүдийн ангирал.

б су Цагаатгах, Цагаатгал.

в су Ариусгал.

г су Ариун байдал.

34а су Сүнс.

б су Амилуулалт.

в су Есүс Христ—

Шүүгч.

г су Иехова.

д Иаков 6:13.

е 1 Тес. 4:17.

ё су Диваажин.

жсу Амрах.

ТӨГСӨВ

СУРГААЛ БА ГЭРЭЭ

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН

ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМИЙН

БОШИГЛОГЧ ИОСЕФ СМИТЭД

БОЛОН СҮМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ ДЭХ

ТҮҮНИЙ ЗАЛГАМЖЛАГЧДАД

ӨГӨГДСӨН ЗАРИМ НЭМЭЛТ

ИЛЧЛЭЛТҮҮДИЙГ АГУУЛДАГ

УДИРТГАЛ

Сургаал ба Гэрээ бол эцсийн өдрүүдэд дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулах болон зохицуулахын тулд өгөгдсөн бурханлиг илчлэлтүүд хийгээд сүнсээр ирсэн тунхаглалуудын цуглуулга болой. Олонх хэсэг нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдэд хандсан хэдий ч, захиас, сэрэмжлүүлэг, түүнчлэн тайлбарууд нь бүх хүмүүн төрөлхтний ашиг тусын төлөө бөгөөд газар бүрийн бүх хүмүүст Их Эзэн Есүс Христийн дуу хоолойг сонсох урилгыг агуулан, тэдний цаг зуурын сайн сайхан байдал хийгээд мөн тэдний мөнхийн авралын төлөө тэдэнд хандан ярьдаг билээ.

Энэхүү эмхэтгэл дэх илчлэлтүүдийн олонх нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн анхны бошиглогч бөгөөд ерөнхийлөгч Бага Иосеф Смитээр дамжин хүлээн авагдсан юм. Бусад нь Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх түүний зарим залгамжлагчдаар дамжуулан өгөгдсөн бөлгөө (хэсэг 135, 136 болон 138-ын гарчгууд түүнчлэн Албан Тунхаг 1, 2-ыг үз).

Сургаал ба Гэрээ ном бол Ариун Библи, Мормоны Ном, түүнчлэн Агуу Үнэт Сувдын хамт Сүмийн жишиг бүтээлүүдийн нэг юм. Гэсэн хэдий ч, энэ нь эртний баримт бичгүүдийн орчуулга биш, харин орчин үеийн гарал үүсэлтэй бөгөөд Бурханаас өөрийн сонгосон бошиглогчдоор дамжуулан өөрийн ариун ажлыг сэргээх хийгээд өнөө үед дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулахын тулд өгөгдсөн учраас Сургаал ба Гэрээ нь хосгүй өвөрмөц юм. Илчлэлтүүдэд цаг хугацааны бүрэн байдлын эрин үед дахин шинээр ярьж буй Их Эзэн Есүс Христийн намуухан атлаа хүчтэй дуу хоолойг хүн сонсох бөгөөд энд үүсгэгдсэн ажил нь түүний хоёр дахь ирэлтэд бэлтгэх, дэлхийн эхлэлээс хойшхи бүх ариун бошиглогчдын үгсийн биелэлт хийгээд тохирол болох бөлгөө.

Бага Иосеф Смит 1805 оны арванхоёрдугаар сарын 23-нд Вермонт муж улсын Виндсор гүнлэгийн Шаронд төржээ. Амьдралынхаа эхэн үед тэрээр гэр бүлийнхээ хамт баруун Нью-Йоркийн Манчестерт шилжжээ. 1820 оны хавар арвандөрвөн настайдаа тэрээр Манчестерын ойролцоо амьдарч байхдаа Мөнхийн Эцэг, Бурхан, түүний Хүү Есүс Христ өөрсдийн биеэр хүрэлцэн ирсэн анхны үзэгдлээ харсан юм. Тэрхүү үзэгдэлд Шинэ Гэрээний үед байгуулагдаж, сайн мэдээний бүрэн байдлыг гүйцэтгэж байсан Есүс Христийн үнэн Сүм дэлхий дээр байхаа больсныг түүнд хэлжээ. Бурханлиг бусад тунхгуудыг дараа нь олон тэнгэр элч түүнд зааж; дэлхий

дээр түүгээр хийлгэх тусгай ажил Бурханд байгааг мөн түүгээр дамжуулж Есүс Христийн Сүм дэлхий дээр сэргээгдэх нь түүнд үзүүлэгдсэн байлаа.

Тэр үед Иосеф Смит бурханлиг тусламжаар Мормоны Номыг орчуулж, мөн хэвлүүлэх боломжийг олсон бөлгөө. Мөн тэр үед 1829 оны тавдугаар сард тэрээр Оливер Каудерийн хамт Иохан Баптистаар Аароны санваарт томилогдсон байлаа (С ба Г 13-г үз), мөн үүнээс хойш удалгүй тэд эртний Төлөөлөгчид Петр, Иаков болон Иоханаар Мелкизедек санваарт томилогдсон байв (С ба Г 27:12–ыг үз). Санваарын түлхүүрүүдийг тэдэнд хүртээсэн бусад томилолтуудыг дараа нь тэдэнд Мосе, Елиа, Елиас болон эртний олон бошиглогчид олгожээ (С ба Г 110; 128:18, 21–ийг үз). Чухамдаа эдгээр томилолтууд нь дэлхий дээр хүмүүнд бурханлиг эрх мэдлийг сэргээжээ. 1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд тэнгэрлэг чиглүүллийн дор Бошиглогч Иосеф Смит Сүмийг зохион байгуулсан бөгөөд тийнхүү Есүс Христийн үнэн Сүм хүмүүний дунд байгууллагын хувьд сайн мэдээг заах хийгээд авралын ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэлтэйгээр нэгэнтээ үйл ажиллагаа явуулж эхэлсэн билээ. (Агуу Үнэт Сувд, Иосеф Смит–Түүх 1:1-75; мөн С ба Г 20-ийг үз.)

Эдгээр ариун илчлэлтүүд нь хэрэгтэй цаг үед залбирлын хариуд хүлээн авагдсан бөгөөд бодит хүмүүс оролцсон бодит амьдралын нөхцөл байдлаас үүдэлтэй байв. Бошиглогч хийгээд сүмийн бусад удирдагчид бурханлиг удирдамжийг эрэлхийлж байсан бөгөөд эдгээр илчлэлтүүд нь тэд үүнийг хүлээн авсныг нотолдог. Есүс Христийн сайн мэдээний сэргэлт болон нээлт мөн цаг хугацааны бүрэн байдлын эрин үеийн эхлэл ирж буйг хүн илчлэлтүүдэд харах бөлгөө. Сүм Нью-Йорк болон Пеннсилванигаас баруун зүгт Огайо, Миссури, Иллиной, эцэст нь өрнөд Америкийн Агуу Их Сав газарт шилжин очсон хийгээд өнөө үед дэлхий дээр Сионыг байгуулах хүчин чармайлтад гэгээнтнүүдийн хийсэн хүчирхэг тэмцлүүд эдгээр илчлэлтүүдэд тэрчлэн үзүүлэгддэг.

Эхний хэдэн хэсэг нь Мормоны Номыг орчуулах болон хэвлүүлэхтэй холбогдсон асуудлуудыг багтаадаг (хэсэг 3, 5, 10, 17, мөн 19-ийг үз). Сүүлчийн зарим хэсгүүд нь сүнсээр удирдагдсан Библийн орчуулга хийх үе дэх Бошиглогч Иосеф Смитийн ажлыг тусгасан бөгөөд энэ үед номлолын олон агуу хэсгүүд хүлээн авагдсан болой (жишээ нь, хэсэг 37, 45, 73, 76, 77, 86, 91, 132-г үз, эдгээр нь тус бүрдээ Библийн орчуулгатай зарим талаар шууд холбоотой юм).

Сайн мэдээний сургаалууд нь Бурхан тэргүүтний мөн чанар,

хүний гарал үүсэл, Сатаны бодит байдал, мөнх бус байдлын зорилго, дуулгавартай байдлын зайлшгүй хэрэгцээ, наманчлалын хэрэгцээ, Ариун Сүнсний ажлууд, авралд хамаарах ёслолууд хийгээд гүйцэтгэлүүд, дэлхийн хувь тавилан, Амилуулалт ба Шүүлтийн дараах хүмүүний ирээдүйн нөхцөл байдал, гэрлэлтийн харилцааны мөнх байдал хийгээд гэр бүлийн мөнх шинж чанар мэтийн тулгуур асуудлуудын тухай тайлбаруудтайгаар илчлэлтүүдэд орсон буюу. Ийм байдлаар бишопууд, Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын Зөвлөл, Далыг дуудаж, мөн тэргүүлэгч бусад албан тушаалууд хийгээд чуулгуудыг байгуулснаар Сүмийн захиргааны бүтэц алгуураар нээгдэн үзүүлэгдсэн юм. Эцэст нь Есүс Христийн талаар өгөгдсөн гэрчлэл–түүний бурханлиг чанар, түүний сүр жавхлан, түүний төгс чанар, түүний хайр, мөн түүний гэтэлгэгч хүч–энэ номыг хүн төрөлхтөнд асар их үнэ цэнэтэй, мөн бүх дэлхийн баялагаас ч илүү үнэ цэнэтэй болгодог.

Нилээд олон тооны илчлэлтүүд 1833 онд Сионд (Индепенденс), Миссурид *Христийн Сүмийн Удирдлагад Өгсөн Зарлигуудын Ном* нэртэйгээр хэвлэгдсэн билээ. Энэхүү нийтлэлийн хувьд Их Эзэн өөрсдийнх нь бодгальд эдгээр илчлэлтүүд үнэн хэмээн гэрчилсэн тухай Сүмийн ахлагчид чанд гэрчлэл өгчээ. Их Эзэн үйлчлэгчидтэйгээ харилцаагаа үргэлжлүүлснээр 2 жилийн дараа өргөтгөсөн эмхэтгэл *Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Сургаал ба Гэрээ* нэртэйгээр Огайогийн Көртландад хэвлэгдэн гарчээ. 1835 оны энэхүү нийтлэлд Арванхоёр Төлөөлөгчийн бичгээр илэрхийлсэн доорх гэрчлэл хавсралт болон гарчээ:

СУРГААЛ БА ГЭРЭЭ НОМ ҮНЭН БОЛОХ ТУХАЙ АРВАНХОЁР ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГЭРЧЛЭЛ

Энэ зорилгын учир сүмийн дуу хоолойгоор томилогдсон Бага Иосеф Смитээр дамжуулан Их Эзэн Өөрийн Сүмд өгсөн Түүний Зарлигуудын Номны гэрчүүдийн гэрчлэл оршвой:

Тиймийн тул, Их Эзэн, бидэн дээр асгарсан Ариун Сүнсээр дамжуулан эдгээр зарлигуудыг Бурханы сүнслэг удирдамжаар өгсөн бөгөөд бүх хүмүүнд ашиг тустай хийгээд яах аргагүй үнэн гэдгийг бидэнд гэрчлэн үлдээсэн болохыг бид бүх дэлхийн хүмүүн төрөлхтөнд, дэлхийн гадаргуу дээрх хүн бүрд гэрчлэхийг хүсч байна.

Их Эзэн бол бидний туслагч мөн хэмээх энэхүү гэрчлэлийг бид дэлхийд өгдөг; түүнчлэн Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христийн ач ивээлээр дамжин бидэнд энэхүү гэрчлэлийг

дэлхийтэй хуваалцах онцгой боломж олгогдсон юм, үүнд бид үлэмж баясч, үүгээр хүмүүний үрс ашиг тусыг олоосой хэмээн Их Эзэнд ямагт залбирнам.

Арванхоёрын нэрс нь:

Томас Б.Марш	Оорсон Хайд	Виллям Смит
Давид В.Паттен	Виллям. И.МкЛеллин	Оорсон Пратт
Бригам Янг	Парли П.Пратт	Жон Ф.Боинтон
Хибер К.Кимбалл	Лук С.Жонсон	Лайман И.Жонсон байлаа.

Сургаал ба Гэрээний дараачийн хэвлэлүүдэд нэмэлт илчлэлтүүд буюу цэдгийн бусад асуудлууд хүлээн авагдсанаар, түүнчлэн Сүмийн нэр хүнд бүхий цугларалтууд буюу чуулганаар хүлээн зөвшөөрөгдсөнөөр нэмэгдэж орсон билээ.

1835 оны хэвлэлээс эхлэн шашны номлолын долоон цуврал хичээл бас нэмэгдэж орсон байна; эдгээр нь *Итгэлийн тухай лекцүүд* хэмээн нэрлэгддэг байв. Эдгээр нь Огайогийн Көртланд дахь Бошиглогчдын Сургуульд 1834-өөс 1835 онуудад ашиглахын тулд бэлтгэгдсэн байлаа. Номлол хийгээд зааврын хувьд үр ашигтай хэдий ч, эдгээр лекцүүд нь нийт Сүмд илчлэлтүүд болж өгөгдөөгүй буюу толилогдоогүй байсан учир 1921 оны хэвлэлээс хойш Сургаал ба Гэрээнээс хасагдсан байна.

Өнгөрсөн хэвлэлүүдэд, ялангуяа хэсгийн гарчгуудын түүхэн хэсгүүдэд зарим алдаа хэвээр үлдсэн нь тодорхой болсон юм. Иймээс, он сар өдрүүд хийгээд газрын нэрс, мөн тэрчлэн бусад зохих жижиг залруулга энэ хэвлэлд орсон болно. Бичвэрүүдийг түүхийн баримт бичгүүдтэй нийцүүлэх үүднээс эдгээр өөрчлөлтийг хийсэн билээ. Хамгийн сүүлчийн энэ хэвлэлийн бусад онцлогуудад илчлэлтүүд хүлээн авагдсан газарзүйн гол байршлуудыг харуулсан газрын зургууд, харьцуулах ишлэлүүд, хэсгийн гарчгууд хийгээд сэдэвчилсэн хураангуйллууд дахь сайжралтууд багтах бөгөөд энэ бүхэн нь Сургаал ба Гэрээнд өгөгдсөн Их Эзэний захиасыг ойлгон мөн баяр баясал амсахад нь уншигчдад туслах зорилготой юм.

Сургаал ба Гэрээний хэсгүүдэд зориулсан удиртгалууд нь *History of the Church* (Сүмийн түүхийн) лавлагааг агуулдаг. *Сүмийн түүх* нь 1820 оноос 1848 оны хоорондох Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн түүхийн долоон боть шастир болно. Эдгээр ботиуд орчуулагдаагүй учраас зөвхөн англи хэлээр ашиглах боломжтой бөгөөд Сургаал ба Гэрээний энэхүү хэвлэлийн удиртгал хэсэг дэх *Сүмийн Түүхийн* ишлэлүүдийн эх сурвалж нь энэ түүхийн англи хэлээр гарсан ботиудад хамаардаг билээ.

АГУУЛГЫН ОН ДАРААЛАЛ

<i>Цаг хугацаа</i>	<i>Газар</i>	<i>Хэсгүүд</i>
1823 он есдүгээр сар	Манчестер, Нью-Йорк	2
1828 он долдугаар сар	Хармони, Пеннсилльвани	3
Зун	Хармони, Пеннсилльвани	10
1829 он хоёрдугаар сар	Хармони, Пеннсилльвани	4
Гуравдугаар сар	Хармони, Пеннсилльвани	5
Дөрөвдүгээр сар	Хармони, Пеннсилльвани	6, 7, 8, 9
Тавдугаар сар	Хармони, Пеннсилльвани	11, 12, 13
Зургадугаар сар	Фейетте, Нью-Йорк	14, 15, 16, 17, 18
1830 он гуравдугаар сар	Манчестер, Нью-Йорк	19
Дөрөвдүгээр сар	Фейетте, Нью-Йорк	20*, 21
Дөрөвдүгээр сар	Манчестер, Нью-Йорк	22, 23
Долдугаар сар	Хармони, Пеннсилльвани	24, 25, 26
Наймдугаар сар	Хармони, Пеннсилльвани	27
Есдүгээр сар	Фейетте, Нью-Йорк	28, 29, 30, 31
Аравдугаар сар	Фейетте, Нью-Йорк	32*, 33
Арваннэгдүгээр сар	Фейетте, Нью-Йорк	34
Арванхоёрдугаар сар	Фейетте, Нью-Йорк	35, 36, 37
1831 он нэгдүгээр сар	Фейетте, Нью-Йорк	38, 39, 40
Хоёрдугаар сар	Көртланд, Огайо	41, 42, 43, 44
Гуравдугаар сар	Көртланд, Огайо	45, 46, 47, 48, 49
Тавдугаар сар	Көртланд, Огайо	50
Тавдугаар сар	Томпсон, Огайо	51
Зургадугаар сар	Көртланд, Огайо	52, 53, 54, 55, 56
Долдугаар сар	Сион, Жаксон гүнлэг, Миссури	57
Наймдугаар сар	Сион, Жаксон гүнлэг, Миссури	58, 59, 60
Наймдугаар сар	Миссури мөрний дэргэд, Миссури	61, 62
Наймдугаар сар	Көртланд, Огайо	63
Есдүгээр сар	Көртланд, Огайо	64
Аравдугаар сар	Хайрам, Огайо	65
Аравдугаар сар	Оранж, Огайо	66
Арваннэгдүгээр сар	Хайрам, Огайо	1, 67, 68, 69, 133
Арваннэгдүгээр сар	Көртланд, Огайо	70
Арванхоёрдугаар сар	Хайрам, Огайо	71
Арванхоёрдугаар сар	Көртланд, Огайо	72
1832 он нэгдүгээр сар	Хайрам, Огайо	73, 74
Нэгдүгээр сар	Амхерст, Огайо	75
Хоёрдугаар сар	Хайрам, Огайо	76
Гуравдугаар сар	Хайрам, Огайо	77, 78, 79, 80, 81
Дөрөвдүгээр сар	Жаксон гүнлэг, Миссури	82, 83
Дөрөвдүгээр сар	Индепенденс, Миссури	83
1832 он наймдугаар сар	Хайрам, Огайо	99
Есдүгээр сар	Көртланд, Огайо	84

* Дэргэдэх болон ойролцоох газрыг заав.

<i>Цаг хугацаа</i>	<i>Газар</i>	<i>Хэсгүүд</i>
1832 Арваннэгдүгээр сар	Көртланд, Огайо	85
Арванхоёрдугаар сар	Көртланд, Огайо	86, 87*, 88
1833 он хоёрдугаар сар	Көртланд, Огайо	89
Гуравдугаар сар	Көртланд, Огайо	90, 91, 92
Тавдугаар сар	Көртланд, Огайо	93, 94
Зургадугаар сар	Көртланд, Огайо	95, 96
Наймдугаар сар	Көртланд, Огайо	97, 98
Аравдугаар сар	Перрисбург, Нью-Йорк	100
Арванхоёрдугаар сар	Көртланд, Огайо	101
1834 он хоёрдугаар сар	Көртланд, Огайо	102, 103
Дөрөвдүгээр сар	Көртланд, Огайо	104*
Зургадугаар сар	Фишинг Ривер, Миссури	105
Арваннэгдүгээр сар	Көртланд, Огайо	106
1835 он гуравдугаар сар	Көртланд, Огайо	107
Наймдугаар сар	Көртланд, Огайо	134
Арванхоёрдугаар сар	Көртланд, Огайо	108
1836 он нэгдүгээр сар	Көртланд, Огайо	137
Гуравдугаар сар	Көртланд, Огайо	109
Дөрөвдүгээр сар	Көртланд, Огайо	110
Наймдугаар сар	Салем, Массачусетс	111
1837 он долдугаар сар	Көртланд, Огайо	112
1838 он гуравдугаар сар	Фар Вест, Миссури	113*
Дөрөвдүгээр сар	Фар Вест, Миссури	114, 115
Тавдугаар сар	Спринг Хилл, Давис гүнлэг, Миссури	116
Долдугаар сар	Фар Вест, Миссури	117, 118, 119, 120
1839 он гуравдугаар сар	Либерти шорон, Клей гүнлэг, Миссури	121, 122, 123
1841 он нэгдүгээр сар	Науву, Иллиной	124
Гуравдугаар сар	Науву, Иллиной	125
Долдугаар сар	Науву, Иллиной	126
1842 он есдүгээр сар	Науву, Иллиной	127, 128
1843 он хоёрдугаар сар	Науву, Иллиной	129
Дөрөвдүгээр сар	Рамус, Иллиной	130
Тавдугаар сар	Рамус, Иллиной	131
Долдугаар сар	Науву, Иллиной	132
1844 он зургадугаар сар	Науву, Иллиной	135
1847 он нэгдүгээр сар	Винтер Квортерс (одоогийн Небраска)	136
1890 он аравдугаар сар	Солт Лейк Хот, Юта	Албан Тунхаг—1
1918 он аравдугаар сар	Солт Лейк Хот, Юта	138
1978 он зургадугаар сар	Солт Лейк Хот, Юта	Албан Тунхаг—2

* Дэргэдэх болон ойролцоох газрыг заав.

СУРГААЛ БА ГЭРЭЭ

ХЭСЭГ 1

1831 оны арваннэгдүгээр сарын 1-нд Огайогийн Хайрамд Сүмийн ахлагч нарын тусгай чуулганы үеэр Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (Сүмийн Түүх, [History of the Church] 1:221–224). Энэ цагийн өмнө Их Эзэнээс олон илчлэлт хүлээн авагдсан бөгөөд эдгээрийг эмхэтгэн ном хэлбэрээр нийтлүүлэх нь энэ чуулган дээр хэлэлцсэн үндсэн гол сэдвүүдийн нэг байлаа. Энэ хэсэг нь энэ эрин үед өгөгдсөн сургаалууд, гэрээнүүд хийгээд зарлигууд дахь Их Эзэний оршлыг багтаадаг бөлгөө.

1–7, Сэрэмжлүүлгийн дуу хоолой бүх хүмүүст хандсан болой; 8–16, Урвалт хийгээд ёс бус явдал Хоёр дахь Ирэлтийн өмнө тохиох болно; 17–23, Их Эзэний үнэнүүд хийгээд хүчнүүдийг дэлхийд сэргээхээр Иосеф Смит дуудагдав; 24–33, Мормоны Ном авчрагдаж, мөн үнэн Сүм байгуулагдав; 34–36, Амар амгалан нь дэлхийгээс авагдах болно; 37–39, Эдгээр зарлигуудыг судлагтун.

АНХААРАГТУН, Ай, миний ^асүмийн хүмүүс, хэмээн дээд тэнгэрт оршигч хийгээд ^бмэлмий нь бүх хүмүүс дээр байх түүний дуу хоолой хэлэх ажгуу; тийм ээ, үнэнээр би хэлнэ: Холын хүмүүс та нар ^ванхаарагтун; мөн тэнгис далайн арлууд дээрх та нар хамтдаа дуулагтун.

2 Учир нь үнэхээр Их Эзэн

ний “дуу хоолой бүх хүмүүнд хандсан болой, мөн зайлан зугтах ^бхэн ч үгүй; мөн харах нь үгүй нүд гэж үгүй болой, мөн сонсох нь үгүй чих гэж үгүй, бас нэвтрэх нь үгүй ^взүрх сэтгэл гэж үгүй бөлгөө.

3 Мөн “эсэргүүцэгчид туйлын их уй гашууд нэрвэгдэх болно; учир нь тэдний алдсууд дээвэр дээрээс ^бяригдах болно, мөн тэдний нууц үйлүүд илчлэгдэх болно.

4 Мөнхүү эдгээр “эцсийн өдрүүдэд миний сонгосон шавь нарын минь амаар, сэрэмжлүүлгийн ^бдуу хоолой бүх хүмүүст хүрэх болно.

5 Мөнхүү тэд урагш одно мөн хэн ч тэднийг зогсоох нь үгүй, учир нь Их Эзэн би тэдэнд зарлигласан болой.

6 Болгоогтун, энэ бол миний “эрх мэдэл, мөн миний үйлч-

1 *а* 3 Ниф. 27:3;
С ба Г 20:1.
сү Есүс Христийн Сүм.
б С ба Г 38:7–8.
су Бурхан, Бурхан Тэргүүтэн.
в Дэд хууль 32:1.

2 *а* С ба Г 133:16.
б Филип. 2:9–11.
в су Зүрх.
3 *а* су Эсэргүүцэл.
б Лук 8:17; 12:3;
2 Ниф. 27:11;
Морм. 5:8.
4 *а* су Эцсийн өдрүүд,

Хожмын өдрүүд.
б Езек. 3:17–21;
С ба Г 63:37.
су Номлолын ажил; Сэрэмжлэх, Сэрэмжлүүлэг.
6 *а* су Есүс Христ—Эрх Мэдэл.

лэгчдийн эрх мэдэл, мөн Ай, дэлхийн оршин суугчид, та нарт ^бхүргэхээр тэдэнд миний өгсөн зарлигуудын минь номны удиртгал юм.

7 Иймийн тул, Ай хүмүүс та нар, “айж мөн чичрэгтүн, учир нь тэдэнд Их Эзэн миний тунхагласан зүйл ^бхэрэгжих болно.

8 Мөнхүү би та нарт үнэнээр хэлнэ, дэлхийн оршин суугчдад эдгээр мэдээг хүргэн урагш одох тэдэнд үл итгэгч хийгээд “эсэргүүцэгчдийг дэлхий хийгээд тэнгэрт аль алинд нь ^блацдах хүч өгөгдсөн юм;

9 Тийм ээ, үнэхээр, Бурханы “уур хилэн ^бёс бусчууд дээр хэмжээлшгүй ихээр цутгагдах тэр өдөрт тэднийг лацдах ажгуу—

10 Хүн болгонд “ажлынх нь дагуу ^бтөлөөсийг нь төлөхөөр, мөн хүн болгоныг анд нөхрөө хэмждэг тэр хэмжүүрийнх нь дагуу “хэмжихээр Их Эзэн ирэх тэр ‘өдөрт буюу.

11 Иймийн тул Их Эзэний дуу хоолой дэлхийн өнцөг булангуудад, сонсох бүгд нь

сонсож болохын тулд хандсан авай:

12 Бэлтгэгтүн та нар, ирэх тэр зүйлийн төлөө бэлтгэгтүн та нар, учир нь Их Эзэн ойрхон байна;

13 Мөн Их Эзэний “уур дүрэлзэж мөн түүний ^билд тэнгэрт угаагдан, мөн тэр нь дэлхийн оршин суугчид дээр унах болно.

14 Мөн Их Эзэний “гар илчлэгдэх болно; мөн Их Эзэний дуу хоолойг, бас түүний үйлчлэгчдийн дуу хоолойг эс ^бсонсож, бошиглогчид хийгээд төлөөлөгчдийн үгсэд “анхаарал эс тавих тэд хүмүүсийн дундаас ‘тусгаарлагдах өдөр ирнэ;

15 Учир нь тэд миний “ёслолуудаас ^бнүүр буруулж, мөн миний “үүрдийн гэрээг ‘зорчсон билээ;

16 Түүний зөв шударга ёсыг бий болгохын тулд тэд Их Эзэнийг “эрэлхийлдэггүй, харин дэлхийнхтэй адил дүр төрх бүхий өөрийнхөө бурхны ^бдүр төрхийг дуурайн хүн болгон “өөрийнхөө ‘замаар замнадаг бөгөөд тэдний эд

6б С ба Г 72:21.

7а Дэд хууль 5:29;

Ном. үгс 12:13.

б С ба Г 1:38.

8а су Эсэргүүцэл.

б су Лацдах,

Лацдалт.

9а Илч. 19:15–16;

1 Ниф. 22:16–17.

б Мозая 16:2;

ИС—А 1:31, 55.

10а Сур. үгс 24:12;

Алма 9:28; 41:2–5;

С ба Г 6:33.

б Езек. 7:4;

С ба Г 56:19.

су Есүс Христ—

Шүүгч.

в Мат. 7:2.

г су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

13а С ба Г 63:6.

б Езек. 21:3;

С ба Г 35:14.

14а Иса. 53:1.

б 2 Ниф. 9:31;

Мозая 26:28.

в С ба Г 11:2.

г Үйлс 3:23;

Алма 50:20;

С ба Г 50:8; 56:3.

15а су Ёслолууд.

б Иош. 23:16;

Иса. 24:5.

в су Шинэ бөгөөд

үүрдийн Гэрээ.

г су Урвалт.

16а Мат. 6:33.

б Ег. 20:4;

3 Ниф. 21:17.

су Хиймэл шүтээн.

в Иса. 53:6.

г С ба Г 82:6.

хөрөнгө нь ^ахуучирч өгөршин Вавилонд, бүр унах тэрхүү агуу ^вВавилонд мөхөх хиймэл шүүтээнийх бөлгөө.

17 Иймийн тул, Их Эзэн бибээр, дэлхийн ^аоршин суугчид дээр ирэх тэрхүү сүйрлийг мэдэх учраас, өөрийн үйлчлэгч Бага Иосеф Смитийг дуудан, тэнгэрээс түүнд ярьж, мөн түүнд зарлигуудыг өгсөн ажгуу;

18 Мөн түүнчлэн эдгээр зүйлүүдийг тэд дэлхийд тунхаглавал зохино хэмээн зарлигуудыг бусдад өгсөн билээ; мөн энэ бүхэн нь бошиглогчдоор бичигдсэн нь биелэгдэж болохын тулд юм—

19 Хүн анд нөхөртэйгөө зөвлөхгүй, мөн хүмүүний чадварт ^аитгэхгүй байхын тулд дэлхийн ^бсул дорой зүйлүүд урагш гарч ирэх бөгөөд хүч чадалтнууд хийгээд хүчтэнүүдийг унагах болно—

20 Харин хүн болгон Их Эзэн Бурханы, бүр дэлхийн Аврагчийн нэрээр ^аярьж болохын тулд юм;

21 Тэрхүү итгэл бас дэлхий дээр өсч болохын тулд юм;

22 Тэрхүү миний үүрдийн

“гэрээ үндэслэгдэн бий болж болохын тулд юм;

23 Миний ^асайн мэдээний бүрэн байдал ^бсул доройчууд хийгээд эгэл борчуудаар дэлхийн хязгааруудад, мөн хаад хийгээд захирагчдын өмнө ^втунхаглагдаж болохын тулд бөлгөө.

24 Болгоогтун, бибээр Бурхан бөгөөд үүнийг ярилаа; эдгээр ^азарлигууд нь надаас бөгөөд миний үйлчлэгчдэд тэдний сул доройд нь, тэдний ^бхэлний маягаар өгөгдсөн нь тэд ^войлголтод хүрч болохын тулд юм.

25 Мөн тэд алдаа гаргахын хэрээр энэ нь мэдэгдэж болохын тулд бөлгөө;

26 Мөн тэд ^амэргэн ухааныг эрэлхийлэхийн хэрээр тэд зааварлагдаж болохын тулд бөлгөө;

27 Мөн тэд нүгэл үйлдэхийн хэрээр тэд ^агэсгээн цээрлүүлэгдэж, тийн тэд ^бнаманчилж болохын тулд билээ;

28 Мөн тэд ^адаруу байхын хэрээр тэд хүчирхэгжиж, мөн дээрээс адислагдан, мөн цагаас цагт ^бмэдлэгийг хүлээн авч болохын тулд бөлгөө.

29 Мөн нифайчуудын цэдгийг хүлээн авсны дараа,

16d Иса. 50:9.

e С ба Г 64:24; 133:14.
су Бабел, Вавилон;
Дэлхийнх.

17a Иса. 24:1–6.

19a 2 Ниф. 28:31.

су Итгэл.

б Үйлс 4:13;

1 Кор. 1:27;

С ба Г 35:13; 133:58–59.

су Номхон дөлгөөн,
Номхон дөлгөөн

байдал.

20a су Гэрчлэх.

22a С ба Г 39:11.

су Гэрээ; Шинэ
бөгөөд үүрдийн
Гэрээ.

23a су Сайн мэдээ.

б 1 Кор. 1:26–29.

в су Номлолын ажил.

24a 2 Ниф. 33:10–11;

Моро. 10:27–28.

б 2 Ниф. 31:3;

Ифер 12:39.

в С ба Г 50:12.

су Мэдлэг.

26a Иаков 1:5;

С ба Г 42:68.

су Мэргэн ухаан.

27a су Зэмлэх, Зэмлэл.

б су Наманчлах,

Наманчлал.

28a су Даруу, Даруу

байдал.

б су Мэдлэг.

тийм ээ, бүр миний үйлчлэгч Бага Иосеф Смит Бурханы нигүүлслээр дамжуулан, Бурханы хүчээр, “Мормоны Номыг орчуулах хүчийг авч болохын тулд бөлгөө.

30 Мөн түүнчлэн, Их Эзэн миний “гаалалд нийцдэг, бүх дэлхийн гадаргуу дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд ^бсүм, энэ ^асүмийн суурийг тавих, мөн үүнийг тодорхой бус байдлаас хийгээд ‘харанхуйгаас урагш гарган авчрах ^вхүч эдгээр зарлигууд өгөгдсөн тэдэнд байхын тулд, бибээр хувь хүмүүст биш харин сүмд нийтэд нь ярьж байна —

31 Учир нь Их Эзэн бибээр “нүглийг өчүүхэн төдий ч хүлцсэн янзаар хүлээн зөвшөөрч чадах нь үгүй;

32 Гэсэн хэдий ч, наманчилж мөн Их Эзэний зарлигуудыг биелүүлэх тэр нь “өршөөгдөх болно;

33 Мөн “наманчлахгүй тэр нь, хүлээж авсан гэрэл нь ч түүнээс ^аавагдах болой; учир

нь миний “Сүнс хүмүүний төлөө ямагт ‘хичээн зүтгэх нь үгүй хэмээн Түмний Их Эзэн хэлдэг.

34 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлнэ, Ай, дэлхийн оршин суугчид аа: Их Эзэн бибээр эдгээр зүйлүүдийг бүх “хүмүүнд мэдүүлэхийг хүсч байна;

35 Учир нь бибээр хүмүүсийг ялгаварлан “нүүр тал харагч биш, мөн тэрхүү ^бөдөр мөдхөн ирнэ гэдгийг бүх хүмүүн мэдээсэй хэмээн хүсч байна; дэлхийгээс ^аамар амгалан нь авагдаж мөн ‘чөтгөр өөрийн ноёрхолд хүчтэй байх тэр цаг хараахан болоогүй ч, ойрхон байна.

36 Мөн түүнчлэн Их Эзэн “гэгээнтнүүдийнхээ дээр хүчтэй байж, мөн тэдний ^бдунд “хаанчлан, мөн ‘Идумеа буюу дэлхий дээр ^вшүүлтэнд бууж ирэх бөлгөө.

37 Эдгээр “зарлигуудыг судлагтун, учир нь тэдгээр нь үнэн бөгөөд итгэмжлэгдсэн юм, мөн тэдгээрт буй бошиг-

29a су Мормоны Ном.

30a С ба Г 38:10.

б Ефес 4:5, 11–14.

су Үнэн Сүмийн тэмдгүүд.

в су Есүс Христийн

Хожмын Үеийн

Гэгээнтнүүдийн

Сүм; Сайн

мэдээний сэргээлт.

г су Сүнсний

харанхуй

д С ба Г 1:4–5, 17–18.

31a Алма 45:16;

С ба Г 24:2.

су Нүгэл.

32a С ба Г 58:42–43.

су Уучлах.

33a Мозая 26:32.

б Алма 24:30;

С ба Г 60:2–3.

в су Ариун Сүнс.

г Эхл. 6:3;

2 Ниф. 26:11;

Морм. 5:16;

Ифер 2:15;

Моро. 9:4.

34a Мат. 28:19;

С ба Г 1:2; 42:58.

35a Дэд хууль 10:17;

Үйлс 10:34;

Моро. 8:12;

С ба Г 38:16.

б су Эцсийн өдрүүд,

Хожмын өдрүүд.

в С ба Г 87:1–2.

су Амар амгалан;

Цаг хугацааны

тэмдгүүд.

г су Чөтгөр.

36a су Гэгээнтэн.

б Зех. 2:10–11;

С ба Г 29:11;

84:118–119.

в су Есүс Христ—

Христийн Мянган

жилийн хаанчлал.

г су Дэлхий.

д су Шүүх, Шүүлт.

37a су Судрууд.

лолууд хийгээд ^бамлалтууд бүгд биелэгдэх болно.

38 Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, мөн би өөрийгөө зөвтгөх нь үгүй; мөн тэнгэр хийгээд газар үгүй болсон ч, миний “үг алга болох нь үгүй, харин миний өөрийн ^бдуу хоолой байна уу, эсвэл миний ^вүйлчлэгчдийн

дуу хоолой байна уу, энэ нь ‘яг адил, бүгд ^вбиелэгдэх болно.

39 Учрыг болгоогтун, мөн харагтун, Их Эзэн бол Бурхан мөн, бас “Сүнс гэрчилдэг, мөн тэрхүү гэрчлэл үнэн болой, бас тэрхүү ^бүнэн үүрд мөн үргэлж оршино. Амен.

ХЭСЭГ 2

1823 оны есдүгээр сарын 21-ний орой Нью-Йоркийн Манчестер дахь Бошиглогчийн эцгийн гэрт байхад нь, Бошиглогч Иосеф Смитэд тэнгэр элч Моронайн хэлсэн үгсийн хэсэг оршвой (History of the Church, 1:12). Моронай бол эдүгээ дэлхийн өмнө Мормоны Ном хэмээгдэх тэрхүү цэдгийг бүтээсэн олон үеийн түүхчдийн сүүлчийнх нь болой. (Малахи 4:5–6; мөн хэсэг 27:9; 110:13–16; мөн 128:18-тай харьцуул.)

1, Елиа санваарыг илчлэх болно; 2–3, Эцгүүдэд нь өгөгдсөн амлалтууд хүүхдүүдийнх нь зүрх сэтгэлд суулгагдах болно.

БОЛГООГТУН, Их Эзэний ^Багуу хийгээд аймшигт өдөр ирэхийн өмнө, бошиглогч ^бЕлиагийн гараар би та нарт Санваарыг илчлэх болно.

2 Мөн “тэрээр эцгүүдэд нь хийгдсэн ^бамлалтуудыг хүүхдүүдийнх нь зүрх сэтгэлд суулгах болно, мөн хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд уруугаа эргэх болно.

3 Хэрэв энэ нь ийм байхгүй аваас, түүний ирэлтээр бүх дэлхий бүрмөсөн устгагдах болно.

ХЭСЭГ 3

1828 оны долдугаар сард Пеннсилвангийн Хармонид Лихайн ном хэмээн нэрлэгдэж байсан, Мормоны Номын нэгдүгээр хэсгээс ор-

37б С ба Г 58:31;
62:6; 82:10.

38а Хаад. дэд 10:10;
Мат. 5:18; 24:35;
2 Ниф. 9:16;
ИС—А 1:35.

б Дэд хууль 18:18;
С ба Г 18:33–38; 21:5.
су Илчлэлт; Дуу
хоолой.

в су Бошиглогч.

г су Эрх мэдэл;
Сүмийн
удирдагчдыг
дэмжих.

д С ба Г 101:64.

39а 1 Иохан 5:6;
С ба Г 20:27; 42:17.

б су Үнэн.

2 1а С ба Г 34:6–9;
43:17–26.

б Малах. 4:5–6;

3 Ниф. 25:5–6;
С ба Г 110:13–15;
128:17;

ИС—Т 1:38–39.

су Елиа; Санваарын
түлхүүрүүд.

2а С ба Г 27:9; 98:16–17.

б су Нас барагсдын
аврал; Лацдах,
Лацдалт.

чуулагдсан гар бичмэлийн 116 хуудас алга болсонтой холбогдуулан, Бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оршвой. Бошиглогч эдгээр хуудсуудыг өөрийн хяналтаас гаргаж, Мормоны Номын орчуулганд богинохон хугацаагаар бичээчээр үйлчилж асан Мартин Харрист дурамжхан өгчээ. Уг илчлэлт Урим ба Туммимаар дамжин өгөгджээ. (History of the Church, 1:21-23.) (Хэсэг 10-ыг үз.)

1-4, Их Эзэний замнал нэгэн мөнхийн эргэлт авай; 5-15, Иосеф Смит наманчлах ёстой эс бөгөөс орчуулах бэлгийг алдана; 16-20, Лихайн удмыг аврахын тулд Мормоны Ном гарч ирэх болно.

БУРХАНЫ “ажлууд хийгээд төслүүд, мөн зорилгууд хясагдаж болохгүй, мөн тэдгээр нь юу ч биш болж болохгүй.

2 Учир нь “Бурхан тахиралдсан замуудаар явах нь үгүй, бас тэрээр баруун гар тийшээ ч, зүүн гар тийшээ ч эргэх нь үгүй, тэрээр бас хэлснээ өөрчлөх нь үгүй, тиймийн тул түүний зам шулуун бөгөөд “замнал нь нэгэн мөнхийн эргэлт бөлгөө.

3 Хясагддаг нь Бурханы “ажил бус, харин хүмүүний ажил гэдгийг санагтун, санагтун;

4 Учир нь хүн олон илчлэлттэй байж, мөн хүчирхэг олон ажлыг хийх хүчтэй байж

болох хэдий ч, хэрэв тэр өөрийн хүчинд “эрдэн сагсуурвал, мөн Бурханы “зөвлөгөөг үл ойшоож, мөн хувийнхаа тааллын тулгалтад хийгээд “зуурдын хүсэл бодолдоо автагдан дагавал, тэрээр өөр дээр нь ирэх шударга Бурханы “өшөө авалтанд өртөн унах ёстой.

5 Болгоогтун, эдгээр зүйлд чамд итгэл найдвар хүлээлгэсэн болой, гэвч чиний зарлиг хэр зэрэг чанд байсан бэ; мөн түүнчлэн чамд өгөгдсөн амлалтуудыг санагтун, хэрэв чи тэдгээрийг зөрчөөгүй бол.

6 Мөн болгоогтун, Бурханы хуулиуд хийгээд зарлигуудыг чи хичнээн олон удаа “зөрчиж, мөн хүмүүний “ятгалгад хөтлөгдсөн билээ.

7 Учрыг болгоогтун, чи Бурханаас илүүгээр хүмүүнээс “айх ёсгүй байсан билээ. Хэдийгээр хүмүүн нь Бурханы зөвлөгөөг үл ойшоон, мөн түүний үгсийг “эс хэрэгслээ ч гэсэн тэр—

3 1a Дуул. 8:3-9;
С ба Г 10:43.

2a Алма 7:20.
су Бурхан, Бурхан тэргүүтэн.
б 1 Ниф. 10:18-19;
С ба Г 35:1.

3a Үйлс 5:38-39;
Морм. 8:22;
С ба Г 10:43.

4a С ба Г 84:73.
су Бардамнал.

б Иаков 4:10;
Алма 37:37.
су Бурханы зарлигууд;
Зөвлөгөө.

в су Тачаангуй,
Зуурдын.
г су Өс хонзон.

6a С ба Г 5:21;

ИС—Г 1:28-29.

б С ба Г 45:29; 46:7.

7a Дуул. 27:1; Лук 9:26;
С ба Г 122:9.

су Зориг, Зоригтой байдал; Айдас.

б Лев. 26:42-43;

1 Ниф. 19:7;

Иаков 4:8-10.

8 Чи итгэлтэй байх ёстой байсан юм; мөн тэрбээр гараа сунган мөн “дайсны бүх” галт сумны эсрэг чамайг дэмжих байсан юм; мөн “гай зовлон тохиолдох бүрийд тэрбээр чамтай хамт байх байсан юм.

9 Болгоогтун, чи бол Иосеф, мөн чи Их Эзэний ажлыг хийхээр сонгогдсон байсан болой, харин гэм буруугийн улмаас, хэрэв чи сонор сэрэмжгүй байх аваас, чи унах болно.

10 Гэвч санагтун, Бурхан нигүүлсэнгүй юм; тиймийн тул, миний чамд өгсөн зарлигийн эсрэг хийсэн зүйлээ наманчлагтун, мөн чи сонгогдсон хэвээр байгаа, мөн тэр ажилд дахин дуудагдсан бөлгөө;

11 Чи үүнийг хийхгүй л бол чи чөлөөлөгдөн мөн бусад хүмүүсийн адил болох бөгөөд бэлэг чамд цаашид байхаа болино.

12 Мөн чамд Бурханы соёрхсон “орчуулах бэлэг хийгээд хүчийг гараасаа алдсанаараа, чи ариун нандин тэрхүү зүйлийг “ёс бус хүний гарт оруулсан билээ,

13 Бурханы зөвлөгөөг үл ойшоож, мөн Бурханы өмнө хийсэн хамгаас ариун нандин амлалтуудыг зөрчин, мөн өөрийн шүүлтэд итгэн мэр-

гэн ухаандаа “бардамнан сагсуурсан түүний буюу.

14 Мөн энэ нь чи тэрхүү онцгой боломжоо богинохон хугацаанд алдсаны шалтгаан болой—

15 Учир нь чи анхнаасаа л “чиглүүлэгчийнхээ зөвлөгөөг улан дор гишгэгдэхийг нь хүлцлээ.

16 Гэсэн хэдий ч, миний ажил урагш ахих болно, учир нь “Аврагчийн тухай мэдлэг иудейчүүдийн “гэрчлэлээр дамжин дэлхийд ирэхийн хэрээр, бүр тийнхүү Аврагчийн тухай “мэдлэг миний хүмүүст ирэх бөлгөө—

17 Мөн тэдний эцгүүдийнх нь гэрчлэлээр дамжин “нифайчуудад, мөн иаковчуудад, мөн иосефчуудад, түүнчлэн зорамчуудад буюу—

18 Мөн эцгүүдийнхээ ёсон бусын улмаас итгэлгүй байдалд “алгуураар ууссан, өөрсдийн ахан дүүс нифайчуудыг алдсуудынх нь хийгээд жигшүүрт хэргүүдийнх нь учир “устгахыг нь Их Эзэн зөвшөөрсөн “леменчүүд, лемүелчүүд, мөн ишмэилчүүдийн мэдлэгт энэхүү “гэрчлэл ирэх болно.

19 Мөн чухамхүү энэ “зорилгын учир эдгээр цэдгүүдийг агуулагч эдгээр “ялтсууд хадгалагдан үлджээ— өөрийн-

8a су Чөтгөр.

б Ефес 6:16;

1 Ниф. 15:24;

С ба Г 27:17.

в Алма 38:5.

12a С ба Г 1:29; 5:4.

б С ба Г 10:6–8.

13a су Бардамнал.

15a ө.х. Их Эзэн.

16a су Аврагч.

б 1 Ниф. 13:23–25;

2 Ниф. 29:4–6.

в Мозая 3:20.

17a 2 Ниф. 5:8–9.

18a 2 Ниф. 26:15–16.

б Морм. 8:2–3.

в 2 Ниф. 5:14;

Инос 1:13–18.

г су Мормоны Ном.

19a 1 Ниф. 9:3, 5.

б су Алтан ялтсууд.

хөө хүмүүст Их Эзэний хийсэн тэрхүү “амлалтууд биелэгдэж болохын тулд юм;

20 Мөн “леменчүүд эцгүүдийнхээ тухай мэдлэгт ирж, мөн тэд Их Эзэний амлалтуудыг мэдэж болох хийгээд

тэд сайн мэдээнд ^битгэж, мөн Есүс Христийн ач гавьяанд ^внайдан, мөн түүний нэрэн дэх итгэлээр дамжуулан ^галдаршиж, мөн наманчлалаараа дамжуулан тэд аврагдаж болохын тулд буюу. Амен.

ХЭСЭГ 4

1829 оны хоёрдугаар сард Пеннсилъванийн Хармонид Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан түүний эцэг Ахмад Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:28).

1–4, Дуулгавартай зоримог үйлчлэл нь Их Эзэний тохинуулагчдыг авардаг; 5–6, Бурханлиг чанарууд нь тэднийг тохинуулалд тохирохоор болгодог; 7, Бурханы зүйлүүд эрэлхийлэгдэх ёстой.

ЭДҮГЭЭ болгоогтун, “гайхамшигт ажил хүмүүний үрсийн дунд тохиох гэж байна.

2 Тиймийн тул, Ай, Бурханы “үйлчлэлийг эхэлж байгаа та нар эцсийн өдөр Бурханы өмнө ^ббуруугүй зогсож болохын тулд та нар бүхий л ^взүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа түүнд ^гүйлчлэхээ мэдэгтүн.

3 Тиймийн тул, хэрэв та нар Бурханд үйлчлэх хүсэлтэй аваас та нар уг ажилд “дуудагдсан болой;

4 Учрыг болгоогтун, “талбай нь цагаан ^бхадахад бэлэн байна; мөн харагтун, хадуураараа чадлаараа хадаж мөн ^внөөцлөх тэрээр мөхөх нь үгүй, харин өөрийн сүнсэнд авралыг авчрах бөлгөө;

5 Мөн “итгэл, ^бнайдвар, “энэрэл ба ^вхайр мөн Бурханы ^галдар суугийн төлөө ^дбүхнээ зориулах нь түүнийг тэрхүү ажилд тохирохоор болгодог.

6 Итгэл, “ариун журам, мэдлэг, өөрийгөө захирах,

19в 3 Ниф. 5:14–15;
С ба Г 10:46–50.
20а 2 Ниф. 30:3–6;
С ба Г 28:8; 49:24.
б Морм. 3:19–21.
в 2 Ниф. 31:19;
Моро. 6:4.
г Моро. 7:26, 38.
4 1а Иса. 29:14;
1 Ниф. 14:7; 22:8;
С ба Г 6:1; 18:44.
су Сайн мэдээний сэргээлт.
2а су Үйлчлэл.

б 1 Кор. 1:8;
Иаков 1:19;
3 Ниф. 27:20.
в су Зүрх; Оюун.
г Иош. 22:5;
1 Сам. 7:3;
С ба Г 20:19; 76:5.
3а С ба Г 11:4, 15;
36:5; 63:57.
су Дуудах,
Бурханаас дуудагдах,
Дуудлага.
4а Иохан 4:35;

Алма 26:3–5;
С ба Г 11:3; 33:3, 7.
б су Ургац хураалт.
в 1 Тим. 6:19.
5а су Итгэл.
б су Найдвар.
в су Энэрэл.
г су Хайр.
д су Алдар суу.
е Дуул. 141:8;
Мат. 6:22;
Морм. 8:15.
6а су Нөлөөлөх хүч.

⁶тэвчээр, ах дүүсэг ёсны нинжин сэтгэл, бурханлиг чанар, энэрэл, ⁶даруу байдал, ⁷хичээл зүтгэлийг санагтун.

7 “Асуу, тэгвэл та нар хүлээж авах болно; тогш, тэгвэл энэ нь та нарт нээгдэх болно. Амен.

ХЭСЭГ 5

1829 оны гуравдугаар сард Пеннсильванийн Хармонид Мартин Харрисын хүсэлтээр Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:28–31).

1–10, Энэ үеийнхэн Их Эзэний үгийг Иосеф Смитээр дамжуулан хүлээж авах болно; 11–18, Гурван гэрч Мормоны Номыг гэрчлэх болно; 19–20, Өмнөх үеүдийн адил Их Эзэний үг нотлогдох болно; 21–35, Мартин Харрис наманчилж мөн гэрчүүдийн нэг нь байж болно.

БОЛГООГТУН, Би чамд хэлж байна, миний үйлчлэгч Бага Иосеф Смит чиний надаас хүлээн авсан хэмээн гэрчилсэн “ялтсууд чамд байгаа гэсэн гэрчлэлийг миний үйлчлэгч ⁶Мартин Харрис гараас минь авахыг хүссэн учраас;

2 Мөн эдүгээ, болгоогтун, үүнийг чи түүнд хэлэгтүн — чамд ярьсан тэрээр, чамд хэлэхдээ: Их Эзэн бибээр Бурхан болой, мөн өөрийн үйлчлэгч Бага Иосеф Смит чамд эдгээр зүйлүүдийг өгсөн, мөн чи эдгээр зүйлүүдийн “гэрч

болон зогсох ёстой хэмээн чамд зарлигласан бөлгөө;

3 Мөн чамайг миний зарлиг болгосноос өөр “хүмүүст тэдгээрийг үзүүлэхгүй байх ёстой хэмээх гэрээнд би чамайг надтай орох болгосон билээ; мөн би чамд олгохгүй л юм бол, чамд тэдгээрийн дээр ямар ч ⁶хүч байхгүй байх болно.

4 Мөн ялтсуудыг орчуулах бэлэг чамд буй; мөн энэ бол чамд миний өгсөн анхны бэлэг болой; мөн энэ талаарх миний зорилго биелэгдэх хүртэл чи өөр бэлэгт санаархах ёсгүй гэдгийг би чамд зарлигласан билээ; учир нь үүнийг дуусах хүртэл би чамд өөр бэлэг өгөхгүй.

5 Үнэнээр, би чамд хэлж байна, хэрэв дэлхийн оршин суугчид миний үгийг “сонсохгүй бол тэдэнд гаслан тохиох болно;

6 Учир нь энэ цагаас хойш

6б су Тэвчээр.

в су Даруу, Даруу байдал.

г су Хичээл зүтгэл.

7а Мат. 7:7–8;

2 Ниф. 32:4.

су Залбирал.

5 1а су Алтан ялтсууд.

б С ба Г 5:23–24;

ИС—Т 1:61.

2а су Гэрч.

3а 2 Ниф. 27:13. Мөн Мормоны Номны оршил хуудсан дахь Гурван Гэрчийн гэрчлэл

болон Найман

Гэрчийн

гэрчлэлийг үз.

б 2 Ниф. 3:11.

5а Иер. 26:4–5;

Алма 5:37–38;

С ба Г 1:14.

чи “томилогдож мөн урагш одон мөн хүмүүний үрст миний ⁶үгсийг хүргэх болно.

7 Болгоогтун, хэрэв тэд миний үгсэд үл “итгэх аваас, хэдийгээр энэ нь боломжтой байгаад чамд миний итгэмжилсэн эдгээр бүх зүйлийг чи тэдэнд үзүүллээ ч гэсэн, тэд чамд итгэхгүй байж болох юм, үйлчлэгч Иосеф минь.

8 Ай, “итгэлгүй хийгээд ⁶гөжүүд энэ үеийнхэн — тэдний эсрэг миний уур дүрэлзэж байна.

9 Болгоогтун, би чамд үнэнээр хэлнэ, миний үйлчлэгч Иосеф чамд миний итгэл хүлээлгэн өгсөн тэдгээр зүйлүүдийг би өөрт буй ухаалаг зорилгын учир, мөн энэ нь ирээдүйн үеийнхэнд мэдэгдэхийн тулд “хадгалж ирсэн билээ;

10 Харин энэ үеийнхэн миний үгийг чамаар дамжуулан хүлээн авах болно;

11 Мөн миний дуудаж мөн томилон, эдгээр зүйлүүдийг тэдэнд миний үзүүлэх миний гурван гэрчийн “гэрчлэл, чиний гэрчлэл дээр нэмэгдэн, мөн тэд чамаар дамжин өгөгдсөн миний үгстэйгээр урагш одох болно.

12 Тийм ээ, эдгээр зүйлүүд үнэн гэдгийг тэд гарцаагүй мэдэх болно, учир нь тэнгэрээс би үүнийг тэдэнд тунхаглах болно.

13 Тэд эдгээр зүйлүүдийг байгаагаар нь болгоож мөн үзэх хүчийг би тэдэнд өгөх болно;

14 Мөн миний “сүм аглаг буйдаас ⁶сар мэт тунгалаг, нар мэт гэрэлтэн мөн туг хиур бүхий их цэрэг мэт сүртэйеэ өндийн өсч урагш гарч ирэхийн эхлэлд, энэ үеийнхний дунд чухам энэхүү гэрчлэлийг хүлээн авах энэ хүчийг би өөр “хэнд ч эс соёрхох болой.

15 Мөн миний үгний талаарх гурван “гэрчийн гэрчлэлийг би илгээх болно.

16 Мөн болгоогтун, миний үгст “итгэх хэнд ч болов, тэдэнд би ⁶Сүнснийхээ “илэрхийллээр ‘айлчлах болно; мөн тэд надаас, бүр ус хийгээд Сүнснээс ⁶төрөх болно —

17 Мөн та нар бага зэрэг хүлээх ёстой, учир нь та нар хараахан “томилогдоогүй байна —

18 Мөн хэрэв тэд зүрх сэтгэлээ тэдний эсрэг хатууруулах аваас тэдний гэрчлэл энэ

6a С ба Г 20:2-3.
су Томилох,
Томилолт.
б 2 Ниф. 29:7.
7a Лук 16:27-31;
С ба Г 63:7-12.
8a су Итгэлгүй
байдал.
б Морм. 8:33.
су Бардамнал.
9a Алма 37:18.
11a 2 Ниф. 27:12;

Ифер 5:3-4;
С ба Г 17:1-5.
14a С ба Г 105:31; 109:73.
б су Есүс Христийн
Сүм; Сайн
мэдээний сэргээлт.
в 2 Ниф. 27:13
15a С ба Г 17:1-20.
су Мормоны
Номны гэрчүүд.
16a Ифер 4:11.
б су Ариун Сүнс.

в С ба Г 8:1-3.
г 1 Ниф. 2:16.
д су Баптисм,
Баптисм хүртээх;
Дахин төрөх,
Бурханаас төрөх;
Ариун Сүнсний
бэлэг.
17a су Эрх мэдэл;
Томилох,
Томилолт.

үеийнхэнд “зэмлэл болж тэрчлэн урагш гарч ирэх болно;

19 Учир нь, мөн хэрэв тэд үл “наманчлах аваас, дэлхий ^бхоосон болж, мөн түүний оршин суугчид миний “ирэлтийн гялбаагаар арчигдан мөн бүрмөсөн устгагдах хүртэл эзгүйрүүлэгч аймшигт “цээрлүүлэлт дэлхийн оршин суугчдын дунд илгээгдэж, цагаас цагт цутгагдан үргэлжлэх болно.

20 Болгоогтун, би чамд эдгээр зүйлүүдийг ярьж байна, бүр Иерусалимын устгалын талаар би түүнчлэн хүмүүст “ярьсны адилаар буюу; мөн миний ^бүг өмнө нь нотлогдож байсны адилаар энэ цагт нотлогдох болно.

21 Мөн эдүгээ, наманчилж, мөн миний өмнө илүү цэх шулуун алхаж, мөн цаашид хүмүүний ятгалгад автахгүй байхыг миний үйлчлэгч Иосеф, би чамд зарлиглаж байна;

22 Мөн чамд миний зарлигласан зарлигуудыг “сахихад чи чанд хатуу байгтун; мөн хэрэв чи үүнийг хийх аваас, болгоогтун, бүр чи ^балагдах байлаа ч гэсэн, би чамд мөнх амьдралыг соёрхоно.

23 Мөн эдүгээ, дахин, миний үйлчлэгч Иосеф, чамд тэрхүү гэрчийг хүсэгч “хүний талаар би хэлж байна—

24 Болгоогтун, би түүнд хэлье, тэрбээр өөрийгөө өргөмжилж, мөн миний өмнө өөрийгөө хангалттайгаар даруу болгосон нь үгүй; гэвч хэрэв тэр зүрх сэтгэлийнхээ эрмэлзлэлээр хүчирхэг залбирал хийгээд итгэлд өөрийгөө даруусган, миний өмнө мэхийвэл, тэгвэл түүний үзэхийг хүсч байгаа тэр “зүйлүүдийг үзэх боломжийг би түүнд соёрхох болно.

25 Мөн тэгээд тэрээр энэ үеийн хүмүүст хэлэх болно: Болгоогтун, Бага Иосеф Смитэд Их Эзэн үзүүлсэн тэр зүйлүүдийг би үзсэн, мөн тэдгээрийн үнэн гэдгийг би лавтайяа “мэднэ, учир нь би тэдгээрийг харсан билээ, учир нь тэдгээр нь хүмүүний бус, харин Бурханы хүчээр надад үзүүлэгдсэн билээ.

26 Мөн Их Эзэн бибээр өөрийн үйлчлэгч Мартин Харристан: Би тэдгээрийг харсан, мөн тэдгээр нь Бурханы хүчээр надад үзүүлэгдсэн гэж хэлэхээс бусдаар тэрээр эдгээр зүйлүүдийн талаар

18a 1 Ниф. 14:7;
С ба Г 20:13–15.

19a су Наманчлах,
Наманчлал.
Эцсийн өдрүүд,
Хожмын өдрүүд;
Цаг хугацааны
тэмдгүүд.
б Иса. 24:1, 5–6.
в Иса. 66:15–16;
С ба Г 133:41.

су Есүс Христийн
Хоёр дахь Ирэлт.
г С ба Г 29:8; 35:11;
43:17–27. су
20a 1 Ниф. 1:18;
2 Ниф. 25:9.
б С ба Г 1:38.

22a су Дуулгавартай
байх, Дуулгавар-
тай, Дуулгавартай
дагах.

б Алма 60:13;
С ба Г 6:30; 135:1–7.

23a С ба Г 5:1.

24a Мормоны Номны
оршил хуудсан
дахь Гурван
Гэрчийн
гэрчлэлийг үз.

25a Ифер 5:3.

тэдэнд илүүг хэлэхгүй байхыг түүнд зарлиглаж байна; мөн эдгээр нь түүний хэлэх үгс болой.

27 Гэвч хэрэв тэр үүнийг үгүйсгэх аваас, өмнө нь надтай хийсэн гэрээгээ тэрээр зөрчих болно, мөн болгоогтун, тэрээр буруутгагдах болно.

28 Мөн эдүгээ, тэрээр өөрийгөө даруусгаж мөн өөрийн хийсэн тэрхүү буруу зүйлүүдийг надад хүлээж, мөн миний зарлигуудыг дагана хэмээн надтай гэрээнд орж, мөн надад итгэх итгэлээ хөгжүүлэхээс нааш, болгоогтун, тэр ийм зүйлүүдийг үзэх боломжгүй, учир нь өөрийнхөө ярьсан тэр зүйлүүдийг үзэх боломжийг би түүнд өгөх нь үгүй хэмээн би түүнд хэлж байна.

29 Мөн хэрэв энэ нь ийм байх аваас, тэрээр цашид ингэхгүй, энэ асуудлын талаар цашид надад аливаа төвөг учруулахгүй байхыг миний үйлчлэгч Иосеф чи түүнд хэлэхийг би чамд зарлиглаж байна.

30 Мөн хэрэв энэ нь ийм байх аваас, болгоогтун, би чамд хэлнэ, Иосеф, чи дахиад хэдэн хуудас орчуулаад чи богинохон хугацаанд зогсох

ёстой, бүр намайг чамд дахин зарлиглах хүртэл буюу; тэгээд чи дахин орчуулж болно.

31 Мөн чи үүнийг хийхээс бусдаар, болгоогтун, чамд бэлэг цаашид байх нь үгүй, мөн чамд итгэл хүлээлгэсэн тэр зүйлүүдээ би татаж авах болно.

32 Мөн эдүгээ, чамайг устгахаар хуйвалдаж буйг би угтан харж байна, тийм ээ, хэрэв миний үйлчлэгч Мартин Харрис өөрийгөө эс даруусгаж мөн миний гараас гэрчийг эс хүлээн авбаас, тэрээр гэм бурууд унах болно гэдгийг би угтан харж байна;

33 Мөн чамайг дэлхийн гадаргуугаас “устгахаар хуйвалдаж байгаа нь олон буй; мөн чиний өдрүүд уртасч болох энэхүү шалтгааны учир эдгээр зарлигуудыг би чамд өглөө.

34 Тийм ээ, энэхүү шалтгааны учир би хэлсэн болой: Зогсогтун, мөн намайг чамд зарлиглах хүртэл хэвээр үлдэгтүн, мөн чамд миний зарлигласан тэр зүйлийг чи биелүүлж болох аргаар би “хангах болно.

35 Мөн хэрэв чи миний зарлигуудыг дагахад “итгэлтэй байх аваас, чи эцсийн өдөр ^бөргөгдөх болно. Амен.

ХЭСЭГ 6

1829 оны дөрөвдүгээр сард Пеннсилвангийн Хармонид Бошиглогч Иосеф Смит, Оливер Каудери хоёрт өгөгдсөн илчлэлт оршвой.

33a С ба Г 10:6; 38:13, 28.
34a 1 Ниф. 3:7.
35a Ег. 15:26;

С ба Г 11:20.
б Иохан 6:39–40;
1 Тес. 4:17;

3 Ниф. 15:1;
С ба Г 9:14; 17:8;
75:16, 22.

(History of the Church, 1:32–35). *Оливер Каудери* 1829 оны дөрөвдүгээр сарын 7-нд Мормоны Номны орчуулгад бичээчийн хөдөлмөрөө эхлэв. Мормоны Номны цэдэг дээр нь сийлбэрлэгдсэн ялтсуудын талаарх Бошиглогчийн гэрчлэл үнэн болох тухай бурханлиг илчлэлтийг тэрээр аль хэдийн хүлээн авсан байлаа. Урим ба Туммимаар дамжуулан Бошиглогч Их Эзэнээс асууж, мөн энэхүү хариуг хүлээж авчээ.

1–6, Их Эзэний талбайд хөдөлмөрлөгсөд авралыг олдог; 7–13, Авралын бэлгээс агуу бэлэг гэж үгүй; 14–27, Үнэний гэрч нь Сүнсний хүчээр ирдэг; 28–37, Христ өөд харагтун, мөн сайныг байнга үйлдэгтүн.

АГУУ хийгээд “гайхамшигт ажил хүмүүний үрст тохиох гэж байна.

2 Болгоогтун, Би Бурхан болой; амьд хийгээд хүчирхэг, хоёр талдаа иртэй илднээс илүү “хурц, үе мөч болон чөмгийг хоёуланг нь хэдэн хэсэг болгон салгах миний үгэнд анхаарал тавигтун; тиймийн тул миний ^бүгст анхаарал тавигтун.

3 Болгоогтун, “талбай нь цагаан хадахад бэлэн байна; тиймийн тул, тэрээр сүнснийхээ төлөө үүрдийн авралыг Бурханы хаант улсад нөөцөлж болохын тулд хураахыг хүсэгч хэн боловч тэрээр хадуураараа чадлаараа хадаг

мөн өдөр үргэлжилж байхад хурааг.

4 Тийм ээ, “хадуураараа хадгаж мөн хураах хэн боловч, тэр нь Бурханаас дуудагддаг бөлгөө.

5 Тиймийн тул, чи надаас “асуух аваас чи хүлээж авах болно; хэрэв чи тогших аваас энэ нь чамд нээгдэх болно.

6 Эдүгээ, чи асуусан болохоор, болгоогтун, би чамд хэлж байна, миний зарлигуудыг сахигтун, мөн “Сионы ашиг сонирхлыг авчирч мөн төлөвшүүлэхийг ^бэрэлхийлэгтүн;

7 “Баялгуудыг бус харин ^бмэргэн ухааныг “эрэлхийлэгтүн, мөн болгоогтун, Бурханы ^внууцууд чамд нээгдэх болно, мөн тэгээд чи баян болгогдох болно. Болгоогтун, ^бмөнх амьдралтай тэр нь баян бөлгөө.

8 Үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, бүр чи надаас хүсэх аваас энэ нь чамд хийгдэх болно; мөн хэрэв чи хүсэх

6 1а Иса. 29:14;
С ба Г 4:1–7; 18:44.
2а Хил. 3:29;
С ба Г 33:1.
б Евр. 4:12; Илч. 1:16;
С ба Г 27:1.
3а Иохан 4:35;
С ба Г 31:4; 33:3;
101:64.

4а Илч. 14:15–19;
Алма 26:5;
С ба Г 11:3–4, 27.
5а Мат. 7:7–8.
6а су Сион.
б 1 Ниф. 13:37.
7а Хаад, дээд 3:10–13;
Мат. 19:23;
Иаков 2:18–19.

су Баялгууд;
Дэлхийнх.
б су Мэргэн ухаан.
в Алма 39:14;
С ба Г 68:31.
г С ба Г 42:61, 65.
су Бурханы
нууцууд.
д С ба Г 14:7.

аваас, чи энэ үед олон сайн зүйлийг хийх арга хэрэгсэл байх болно.

9 Энэ үеийнхэнд “наманчлалаас өөр юу ч бүү ярь; миний зарлигуудыг сахигтун, мөн миний зарлигуудын дагуу миний ажлыг урагшлуулахад туслагтун, мөн чи адислагдах болно.

10 Болгоогтун чамд бэлэг буй, бэлгийнхээ улмаас чи адислагдсан бөлгөө. Энэ нь “ариун нандин хийгээд дээрээс ирдгийг санагтун —

11 Мөн чи “асуух аваас, чи агуу хийгээд гайхамшигтай ^бнууцуудыг мэдэх болно; тиймийн тул, чи нууцуудыг мэдэж, чи олныг үнэний мэдлэгт авчирч болохын тулд, тийм ээ, өөрсдийнх нь замын бурууг тэдэнд ^аитгүүлэхийн тулд чи ^вбэлгээ ашиглагтун.

12 Тэд чамтай итгэл нэг бус аваас өөр хэнд ч чи өөрийнхөө бэлгийг бүү мэдүүл. “Ариун нандин зүйлүүдэд бүү хөнгөн хуумгай ханд.

13 Хэрэв чи сайныг үйлдвээс, тийм ээ, мөн “эцсээ хүртэл ^битгэлтэйгээр ^атэсэх аваас, чи Бурханы бүх бэлгүүдээс хамгийн агуу нь болох Бурханы хаант улсад аврагдах

болно; учир нь ‘авралын бэлгээс илүү агуу бэлэг гэж үгүй билээ.

14 Үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, чи хийсэн тэр зүйлийнхээ төлөө адислагдсан болой; учир нь чи надаас “асуусан билээ, мөн болгоогтун, чи асуух тоолондоо, чи миний Сүнснээс заавар хүлээж авсан бөлгөө. Хэрэв энэ нь ийм байгаагүй аваас, чи энэ цагт өөрийнхөө байгаа тэр газарт хүрч ирэхгүй байх байсан.

15 Болгоогтун, чи надаас асууснаа мэдэж байгаа мөн бибээр чиний “оюуныг гэгээрүүлсэн билээ; мөн үнэний Сүнсээр гэгээрсэн гэдгээ чамайг мэдээсэй гэсэндээ би эдгээр зүйлүүдийг чамд хэлж байна;

16 Тийм ээ, Бурханаас өөр чиний санаа бодол хийгээд “зүрх сэтгэлийн тань хүсэл эрмэлзлэлийг ^бмэдэх хэн ч үгүй гэдгийг чи мэдэж болохын тулд би чамд хэлж байна.

17 Би эдгээр зүйлийн гэрч болохын хувьд чамд хэлж байна — чиний бичиж буй үгс буюу ажил “үнэн билээ.

18 Тиймийн тул “хичээнгүй байгтун; энэ үгний төлөө түү-

9а Алма 29:9;
С ба Г 15:6;
18:14–15; 34:6.
су Номлолын
ажил; Наманчлах,
Наманчлал.
10а С ба Г 63:64.
11а С ба Г 102:23;
ИС—Т 1:18, 26.
б Мат. 11:25; 13:10–11;
Алма 12:9.

в Иаков 5:20;
Алма 62:45;
С ба Г 18:44.
г су Бэлэг; Сүнсний
бэлгүүд.
12а Мат. 7:6.
13а су Тэвчих.
б Мозая 2:41;
Ифер 4:19;
С ба Г 51:19; 63:47.
в 1 Ниф. 15:24.

г су Аврал.
14а су Залбирал.
15а су Оюун.
16а Хаад. дээд 8:39.
б Шаст. дээд 28:9;
Мат. 12:25; Евр. 4:12;
Мозая 24:12;
3 Ниф. 28:6.
су Бүхнийг Мэдэгч.
17а С ба Г 18:2.
18а су Хичээл зүтгэл.

нийг аливаа хүнд байдалд ороход нь миний үйлчлэгч Иосефын дэргэд итгэлтэйгээр ⁶зогсогтун.

19 Дутагдалд нь түүнд сануулж байгтун, мөн түүнчлэн түүнээс сануулга зөвлөгөө авч бай. Тэвчээртэй бай; хэрсүү бай; биеэ барьж бай; тэвчээр, итгэл, найдвар хийгээд энэрэлтэй бай.

20 Болгоогтун, чи бол Оливер, чиний хүслийн учир би чамд ярилаа; тиймийн тул эдгээр үгсийг зүрх сэтгэлдээ “нөөцөл. Бурханы зарлигуудыг дагахад итгэлтэй хийгээд хичээнгүй байгтун, мөн би чамайг хайрынхаа мутарт гэвэрнэм.

21 Болгоогтун, би бол Есүс Христ, Бурханы “Хүү бөлгөө. Би бол ⁶өөрийнхөндөө ирсэн тэр бөгөөд өөрийнхөн маань намайг хүлээн авсангүй. Би бол “харанхуйд гялалзагч гэрэл бөгөөд харанхуй нь үүнийг ойлгох нь үгүй.

22 Үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, хэрэв чи дахин нэмэлт гэрчийг хүсэх аваас, чи зүрх сэтгэлдээ эдгээр зүйлүүдийн үнэний талаар чи “мэдэхийн тулд надад хандан залбирсан тэр шөнийг оюундаа санагтун.

23 Энэ асуудлын талаар чиний оюунд “амар амгаланг би яриагүй билүү? Бурханаас илүү агуу ямар ⁶гэрч чамд байж болох билээ?

24 Мөн эдүгээ, болгоогтун, чи гэрчийг хүлээж авлаа; учир нь би чамд ямар ч хүмүүний үл мэдэх тэр зүйлүүдийг ярьсан байхад чи гэрчийг хүлээж аваагүй байна гэж үү?

25 Мөн, болгоогтун, хэрэв чи надаас хүсэх аваас, бүр миний үйлчлэгч Иосефынхтой адил “орчуулах бэлгийг би чамд соёрхох ажгуу.

26 Үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, хүмүүсийн “ёс бусын улмаас хадгалан үлдээсэн, миний сайн мэдээнээс ихээр агуулагч ⁶цэдгүүд буй;

27 Мөн эдүгээ хэрэв өөрийнхөө төлөө тэнгэрт баялаг хураах—сайн сайхан хүсэл чамд бий аваас—тэгвэл алдсын улмаас нуусан байсан миний “судруудын тэрхүү хэсгүүдийг өөрийнхөө бэлгээр гэрэлд авчрахад чи туслах болно гэдгийг би чамд зарлиглаж байна.

28 Мөн эдүгээ, болгоогтун, би энэхүү тохинууллыг гэрэлд авчрах энэ бэлгийн

18б С ба Г 124:95–96.

20а Ифер 3:21;

С ба Г 84:85.

21а су Есүс Христ.

б Иохан 1:10–12;

Үйлс 3:13–17;

3 Ниф. 9:16;

С ба Г 45:8.

в су Сүнсний

харанхуй.

г Иохан 1:5;

С ба Г 10:58.

су Гэрэл, Христийн

гэрэл.

22а су Ялган таних

бэлэг.

23а су Амар амгалан.

б 1 Иохан 5:9;

С ба Г 18:2.

25а Мозая 8:13;

С ба Г 5:4; 9:1–5, 10.

26а су Ёс бус, Ёс бус байдал.

б С ба Г 8:1; 9:2.

су Судрууд—Ирнэ

хэмээн

бошиглогдсон

судрууд.

27а С ба Г 35:20.

түлхүүрүүдийг чамд, мөн түүнчлэн өөрийн үйлчлэгч Иосефт өгнө; мөн хоёр буюу гурван “гэрчийн аманд үг болгон үндэслэгдэх болно.

29 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, хэрэв тэд миний үгсийг, мөн миний сайн мэдээ хийгээд тохинууллын энэ хэсгийг эсэргүүцэх аваас, та нар адислагдсан байна, учир нь тэд надад хийхээс илүү ихийг та нарт үйлдэж чадах нь үгүй.

30 Мөн бүр тэд надад үйлдсэний адилаар та нарт “үйлдэх аваас, та нар адислагдсан байна, учир нь та нар надтай хамт ^балдар сууд ^ворших бөлгөө.

31 Харин тэд өгөгдөх “гэрчлэлээр үндэслэгдэх миний үгсийг үл ^бэсэргүүцэх аваас, тэд адислагдсан байна, мөн тэгээд та нар хөдөлмөрийнхөө үр шимэнд баяртай байх болно.

32 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, би шавь нартаа хэлж байсны адилаар, хоёр эсвэл гурваараа миний нэрээр, аль нэг зүйлийн талаар

“хамтдаа цугларсан тэнд, болгоогтун, би тэдний ^бдунд байх болно, бүр тэрчлэн би та нарын дунд байдаг.

33 Сайныг үйлдэхээс бүү “ай, хөвгүүд минь, учир нь та нар юу ^бтарина, та нар мөн түүнчлэн хурааж авах болно; тиймийн тул, хэрэв та нар сайныг таривал та нар шагналдаа түүнчлэн сайныг хурааж авах болно.

34 Тиймийн тул, бүү ай, бяцхан сүрэг; сайныг үйлдэгтүн; дэлхий хийгээд там та нарын эсрэг нэгдэг, учир нь хэрэв та нар миний “хадан дээр баригдсан байх аваас, тэд дийлэх нь үгүй.

35 Болгоогтун, би та нарыг зэмлэх нь үгүй; өөрсдийнхөө замаар явж мөн “нүглийг дахин бүү үйлд; та нарт миний зарлигласан ажлыг буурь суурьтайгаар гүйцэтгэгтүн.

36 Санаа бодол болгондоо над уруу “харагтун; бүү эргэлз, бүү ай.

37 Миний хажуу талыг цоо хатгасан шархыг, мөн түүнчлэн миний гар мөн хөлөн дэх “хадаасны ормуудыг ^бболгоог-

28a Дэд хууль 19:15;

2 Кор. 13:1;

2 Ниф. 27:12–14;

С ба Г 128:3.

30a С ба Г 5:22; 135:1–7.

су Санаатайгаар алах, Санаатай аллага.

б су Алдар суу.

в Илч. 3:21.

31a су Гэрчлэл.

б 3 Ниф. 16:10–14;

С ба Г 20:8–15.

32a Мат. 18:19–20.

су Эв нэгдэл.

б С ба Г 29:5; 38:7.

33a су Зориг,

Зоригтой.

б Гал. 6:7–8;

Мозая 7:30–31;

Алма 9:28;

С ба Г 1:10.

34a Дуул. 71:3;

Мат. 7:24–25;

1 Кор. 10:1–4;

Хил. 5:12;

С ба Г 10:69;

18:4, 17; 33:13;

Моце 7:53.

су Хад.

35a Иохан 8:3–11.

36a Иса. 45:22;

С ба Г 43:34.

37a су Цовдлуулалт.

б су Есүс Христ—

Христийн мөнх бус амьдралын дараах ирэлт.

тун; итгэлтэй байгтун, миний зарлигуудыг сахигтун,

мөн та нар тэнгэрийн “хаант улсыг” өвлөх болно. Амен.

ХЭСЭГ 7

1829 оны дөрөвдүгээр сард Пеннсилвангийн Хармонид Бошиглогч Иосеф Смит, Оливер Каудери хоёрыг, хайрт шавь Иохан бие махбодид оршоор байгаа юу эсвэл наснаас хальсан уу гэдгийг Урим ба Туммимаар дамжуулан асуухад өгөгдсөн илчлэлт оршвой. Уг илчлэлт нь илгэн дээр Иоханы хийсэн мөн түүний нуусан цэдгийн хөрвүүлэгдсэн хувилбар болно (History of the Church, 1:35-36).

1-3, Их Эзэнийг иртэл хайрт Иохан амьд байх болно; 4-8, Петр, Иаков, Иохан нар сайн мэдээний түлхүүрүүдийг атгадаг.

МӨН Их Эзэн надад хэлсэн нь: “хайрт Иохан минь, чи юу “хүсээ вэ? Учир нь хэрэв чи хүсч байгаа юмаа асуух аваас, энэ нь чамд соёрхогдох болно.

2 Мөн би түүнд хэлсэн нь: Их Эзэн, би амьдарч, мөн бодгалиудыг танд авчирч болохын тулд “үхлийн дээрх хүчийг надад өгөөч.

3 Мөн Их Эзэн надад хэлэв: Үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, чи үүнийг хүссэн учраас намайг “алдар суундаа иртэл чи “үлдэж, мөн үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүсийн өмнө “бошиглох болно.

4 Мөн энэ шалтгааны учир Их Эзэн Петрт хэлэв: Хэрэв би өөрийгөө иртэл түүнийг

үлдэхийг хүсэх аваас, энэ нь чамд юуны хамаа байна? Учир нь тэр сүнснүүдийг надад авчирч болохын тулд тэрээр надаас хүссэн бөлгөө, харин чи миний “хаант улсад надад түргэн ирж болохын тулд хүсч байгаа ажээ.

5 Би чамд хэлж байна, Петр, энэ бол сайхан хүсэл байсан ажгуу; харин миний хайрт, тэрээр илүү ихийг буюу өмнө нь өөрийнхөө хийснээс илүү агуу ажлыг хүмүүний дунд хийхийг хүсч байна.

6 Тийм ээ, тэрээр агуу ажлыг өөртөө хүлээсэн билээ; тиймийн тул би түүнийг шатаж буй галын дөл мөн “тохинуулах тэнгэр элч мэт болгоно; тэрээр авралыг “залгамжлагчид хийгээд “дэлхий дээр амьдрагч тэдэнд тохинуулах болно.

7 Мөн би чамайг түүнд мөн чиний ах Иаковт тохи-

37в су Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс.

2 Мат. 5:3, 10;
3 Ниф. 12:3, 10.

7 1а су Иохан,
Зебедийн хүү.
б 3 Ниф. 28:1-10.

2а Лук 9:27.

су Биеийн үхэл.
3а су Алдар суу; Есүс Христийн Хоёр дахь Ирэлт.

б Иохан 21:20-23.
су Зөөгдсөн хүмүүн биес.

в Илч. 10:11.

4а су Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс.
6а С ба Г 130:5.

б С ба Г 76:86-88.
в Иохан 10:8-11;
С ба Г 77:14.

нуулах болгоно; мөн энэхүү хүчийг мөн энэ тохинууллын “түлхүүрүүдийг өөрөө ирэх хүртэл би та гуравт өгөх болно.

8 Үнэнээр би та нарт хэлнэ, та хоёр хоёул, хүслүүдийнхээ дагуу авах болно, учир нь та хоёр хоёул хүссэн тэр зүйлдээ “баясах авай.

ХЭСЭГ 8

1829 оны дөрөвдүгээр сард Пеннильванийн Хармонид Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан, Оливер Каудерид өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:36–37). *Мормоны Номын орчуулгын явцад бичээчээр үргэлжлэн үйлчилж, Бошиглогчийн хэлж өгснийг бичиж байсан Оливер орчуулгын бэлгээр хишиг хүртэхийг хүссэн авай. Их Эзэн энэхүү илчлэлтийг соёрхсоноор түүний даруухан залбиралд хариулжээ.*

1–5, Илчлэлт нь Ариун Сүнсний хүчээр ирдэг; 6–12, Бурханы нууцуудын мэдлэг хийгээд эртний цэдгүүдийг орчуулах хүч нь итгэлээр ирдэг.

“ОЛИВЕР Каудери, үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, чиний Бурхан мөн чиний Гэтэлгэгч болох Их Эзэн амьдардаг нь эргэлзээгүйн адил, миний Сүнсний “илэрхийллээр яригдсан судруудын минь тэдгээр хэсгүүдийг агуулсан, эртний хуучин “цэдгүүдийн сийлбэрүүдийн талаарх мэдлэгийг чи хүлээн авна гэдэгт итгэн, үнэнч зүрх сэтгэлээр итгэн ‘асуух ямар ч зүйлүүдийн тухай ‘мэдлэгийг чи бүр лавтайяа хүлээн авах болно.

2 Тийм ээ, болгоогтун, чамд ирж мөн “зүрх сэтгэлд чинь орших “Ариун Сүнсээр оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь би чамд “ярих болно.

3 Эдүгээ, болгоогтун, энэ бол илчлэлтийн сүнс болой; болгоогтун, энэ бол Мосе Израилын хүүхдүүдийг “Улаан Тэнгисийн дундуур хуурай газраар гаталган авчирсан тэр сүнс бөлгөө.

4 Тиймийн тул энэ нь чиний бэлэг болой; үүнийг ашиглагтун, мөн чи адислагдсан бөлгөө, учир нь энэ нь чамайг дайснуудын чинь гараас чөлөөлөх болно, хэрэв энэ нь ийм бус байсан аваас, тэд чамайг алж мөн сүнсийг чинь устгалд авчрах байсан биз ээ.

5 Ай, эдгээр “үгсийг санаг-

7a Мат. 16:19;
 Үйлс 15:7;
 ИС—Т 1:72.
 су Санваарын
 түлхүүрүүд.
 8a су Баяр баясал.
 8 1a ИС—Т 1:66.
 су Оливер

Каудери.
 б С ба Г 5:16
 в С ба Г 6:26–27; 9:2.
 г су Залбирал.
 д су Мэдлэг.
 2a су Зүрх.
 б су Ариун Сүнс.
 в С ба Г 9:7–9.

су Илчлэлт.
 3a Ег. 14:13–22;
 Дэд хууль 11:4;
 1 Ниф. 4:2;
 Мозая 7:19.
 су Улаан Тэнгис.
 5a Дэд хууль 11:18–19.

тун, мөн миний зарлигуудыг сахигтун. Санагтун, энэ нь чиний бэлэг болой.

6 Эдүгээ энэ нь чиний бүх бэлэг бус болой; учир нь чамд өөр нэг бэлэг, Аароны бэлэг буй; болгоогтун, энэ нь чамд олон зүйлийг хэлсэн бөлгөө;

7 Болгоогтун, Бурханы хүчнээс өөр Аароны энэхүү бэлгийг чамтай хамт байлгахад хүргэдэг хүч гэж үгүй болой.

8 Тиймийн тул, бүү эргэлз, учир нь энэ бол Бурханы бэлэг юм; мөн чи үүнийг гартаа атгаж, мөн гайхамшигт ажлуудыг үйлдэх болно; мөн үүнийг чиний гараас суга татан авах хүч гэж байхгүй, учир нь энэ нь Бурханы ажил юм.

9 Мөн, тиймийн тул, тэр

аргаар өөртөө хэлүүлэхээр чи надаас юуг ч асуунав, би чамд өгөх болно, мөн чамд энэ тухай мэдлэг байх болно.

10 “Итгэлгүйгээр чи юу ч хийж чадахгүй гэдгийг санагтун; тиймийн тул итгэлд асуу. Эдгээр зүйлүүдэд бүү хөнгөн хуумгай ханд; гуйх ёсгүй зүйлийг чи бүү ^бгуй.

11 Бурханы нууцуудыг мэдэж болохын тулд, мөн нуусан байсан эртний тэдгээр бүх ариун нандин цэдгүүдээс мэдлэг хүлээн авах хийгээд “орчуулж болохын тулд чи асуугтун; мөн итгэлийн чинь дагуу энэ нь чамд хийгдэх болно.

12 Болгоогтун, үүнийг ярьсан нь бибээр болой; мөн би бол эхлэлээс чамд ярьсан тэр болой. Амен.

ХЭСЭГ 9

1829 оны дөрөвдүгээр сард Пеннсилванийн Хармонид Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Оливер Каудерид өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:37–38). Тэвчээртэй байхыг Оливерт сэрэмжлүүлж, мөн тухайн үед орчуулах гэж оролдохоосоо илүүгээр, орчуулагчийн хэлж өгснийг бичихдээ сэтгэл ханамжтай байхыг сануулав.

1–6, Орчуулагдах ёстой эртний өөр цэдгүүд буй; 7–14, Мормоны Ном сурах хийгээд сүнсний баталгаагаар орчуулагдах авай.

БОЛГООГТУН, хүү минь, Би чамд хэлж байна, чи надаас хүссэний дагуу “орчуу-

лаагүй мөн миний үйлчлэгч Бага Иосеф Смитэд зориулж дахин ^ббичиж эхэлсэн учраас, мөн тийнхүү түүнд миний итгэл хүлээлгэсэн энэхүү цэдгийг дуустал та нар үргэлжлүүлэх ёстой хэмээнэ би.

2 Мөн тэгээд, болгоогтун, орчуулахад нь чи тусалж

10а су Итгэл.
б С ба Г 88:63–65.

11а С ба Г 9:1, 10.
9 1а С ба Г 8:1, 11.

б ИС—Т 1:67.

болох хүчийг би чамд өгөх “бусад” цэдгүүд надад буй.

3 Хүү минь, тэвчээртэй байгтун, учир нь энэ бол надад орших мэргэн ухаан болой, мөн чи эдүгээ энэ цагт орчуулах нь шаардлагатай бус бөлгөө.

4 Болгоогтун, чиний хийхээр дуудагдсан ажил бол миний үйлчлэгч Иосефт зориулж бичих явдал мөн.

5 Мөн, болгоогтун, чи орчуулж эхлэхдээ эхэлсэн шигээ үргэлжлүүлээгүй учир, би энэхүү онцгой боломжийг чамаас авсан билээ.

6 Хүү минь, бүү “бувтна, учир нь би энэ маягаар чамд хандсан нь надад орших мэргэн ухаан буюу.

7 Болгоогтун, чи ойлгосонгүй; чи надаас асуухаас өөрөөр санаа тавиагүй байхад чинь, би үүнийг чамд өгөх юм шигээр чи бодсон байна.

8 Гэвч, болгоогтун, би чамд хэлнэ, чи үүнийг оюундаа “тунгаан бодох ёстой; дараа нь энэ нь зөв үү гэдгийг чи надаас асуух ёстой, мөн энэ нь зөв аваас “цээжин биеийг чинь чиний дотор шатахаар болгоно би; тиймийн тул,

энэ нь зөв юм байна гэдгийг чи мэдрэх болно.

9 Гэвч энэ нь зөв биш аваас чамд ийм мэдрэмж байхгүй байх болно, харин буруу зүйлийг мартахад чамайг хүргэх “дүйнгэ бодол санаа чамд байх болно; тиймийн тул, надаас чамд өгөгдөхөөс бусдаар, ариун нандин тэр зүйлийг чи бичиж чадах нь үгүй болой.

10 Эдүгээ, хэрэв чи үүнийг мэдсэн сэн бол чи “орчуулж чадах байсан; гэсэн хэдий ч, эдүгээ чи орчуулах нь зүйтэй бус бөлгөө.

11 Болгоогтун, чиний эхэлсэн үед энэ нь зүйтэй байлаа; гэвч чи “айсан, мөн цаг нь өнгөрч, мөн энэ нь эдүгээ зүйтэй бус бөлгөө;

12 Учир нь, би үйлчлэгч “Иосефтоо хангалттай хүч чадал өгч түүгээр энэ нь нөхөгдсөнийг чи харахгүй байна гэж үү? Мөн та хоёрын алийг чинь ч би зэмлээгүй байна.

13 Чамд миний зарлигласан энэ зүйлийг хийгтүн, мөн чи дэгжих болно. Итгэлтэй байгтун, мөн “уруу таталтанд бүү авт.

14 Чамайг миний “дуудсан

2a Оливер Каудери бичээч болж тусалсан Библийн Иосеф Смитийн орчуулга болон Абрахамын Номыг хамарсан нэмэлт орчуулгын үйл ажиллагаа гэсэн далд утгатай. Судруудын удирдамж Иосеф Смитийн

орчуулга (ИСО).
су Иосеф Смитийн Орчуулга (ИСО).
б С ба Г 6:26; 8:1.
ба су Бувтнах.
8а су Тунгаан бодох.
б су Залбирал.
в Лук 24:32.
г су Сүнсний удирдамж, Сүнслэгээр нөлөөлөгдөх; Гэрчлэл.

д С ба Г 8:2-3.
9а С ба Г 10:2.
10а С ба Г 8:11.
11а су Айдаас.
12а С ба Г 18:8.
13а су Уруу татах, Уруу таталт.
14а су Дуудах, Бурханаас дуудагдах, Дуудлага.

тэр “ажилд чанд шаргуу зогсогтун, мөн толгойны чинь ширхэг үс ч гээгдэх нь үгүй,

мөн эцсийн өдөр чи “өргөгдөх болно. Амен.

ХЭСЭГ 10

1828 оны зун Пеннсилъванийн Хармонид Бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оривой (History of the Church, 1:20–23). Мормоны Номон доторх Лихайн номны орчуулгын 116 хуудас гар бичмэлд ёс бус хүмүүсийн хийсэн өөрчлөлтүүдийн талаар энд Их Эзэн, Иосеф Смитэд мэдээлэв. Гар бичмэлийн эдгээр хуудсууд Мартин Харрисын эзэмшилд байхад алга болсон бөгөөд хуудсуудыг түүнд түр хугацаагаар итгэл хүлээлгэн өгсөн ажээ (Хэсэг 3-ын толгой гарчгийг үз). Хулгайлагдсан хуудсууд дахь асуудлыг дахин орчуулахыг нь хүлээж, дараа нь өөрчилсний улмаас гарсан зөрүүг нь харуулах замаар орчуулагчийг гутаах нь хилэнцэт төлөвлөгөө байлаа. Энэхүү ёс бус зорилго нь хилэнцэт санаат нэгнээр зохиогдсон бөгөөд бүр эртний нифайчуудын түүхч Мормон хураангуйлсан ялтсуудын товчлол хийж байх үед Их Эзэнд мэдэгдэж, Мормоны Номонд үзүүлэгджээ (Мормоны Үгс 1:3–7-г үз).

1–26, Их Эзэний ажлыг эсэргүүцэхэд Сатан ёс бус хүмүүсийг өдөөн хатгадаг; 27–33, Тэрээр хүмүүний бодгалиудыг устгахыг эрэлхийлдэг; 34–52, Сайн мэдээ нь Мормоны Номоор дамжин леменчүүд хийгээд бүх үндэстнүүдэд хүрэх ёстой; 53–63, Их Эзэн хүмүүний дунд өөрийн Сүм болон өөрийн сайн мэдээг үндэслэх болно; 64–70, Тэрээр наманчлагчдыг өөрийн Сүмд цуглуулж мөн дуулгавартнуудыг аврах болно.

ЭДҮГЭЭ, болгоогтун, би чамд хэлж байна, “Урим ба Туммимын аргаар орчуулах хүч нь чамд өгөгдсөн

тэрхүү бичээсүүдийг чи “ёс бус хүний гарт оруулсны учир, чи тэдгээрийг алдлаа.

2 Мөн түүнчлэн чи яг энэ үед бэлгээ алдаж, мөн “оюун чинь харанхуйлсан буюу.

3 Гэсэн хэдий ч, энэ нь эдүгээ чамд “дахин сэргэсэн болой; тиймийн тул чи итгэлтэй байж мөн орчуулгын ажлын үлдсэнийг эхэлснийхээ адилаар дуусгахаар үргэлжлүүлэхээ мэдэгтүн.

4 Орчуулах боломжийг чамд олгосон өөртөө байгаа “хүч чадал хийгээд аргаас илүү “хурдан гүйх буюу илүүгээр бүү хөдөлмөрлө; харин эцсээ хүртэл “хичээнгүй бай.

146 1 Кор. 16:13.
в Алма 13:29;
С ба Г 17:8.
10 1а су Урим ба

Туммим.
б С ба Г 3:1–15.
2а су Оюун.
3а С ба Г 3:10.

4а Ег. 18:13–26.
б Мозая 4:27.
в Мат. 10:22.
су Хичээл зүтгэл.

5 Ялан дийлэгч болж гарахын тул чи ямагт “залбир; тийм ээ, чи Сатаныг ялж гарахын тулд, мөн түүний ажлыг дэмжиж байдаг Сатаны зарц нарын гараас зугтаахын тулд буюу.

6 Болгоогтун, тэд чамайг “устгахыг эрэлхийлсэн билээ; тийм ээ, бүр чиний итгэсэн тэр ^бхүн чамайг устгахыг эрэлхийллээ.

7 Мөн энэ шалтгааны учир тэр бол ёс бус хүн гэдгийг би хэллээ, учир нь тэрээр чамд итгэл хүлээлгэн өгсөн тэр зүйлүүдийг зайлуулахыг эрэлхийллээ; мөн тэрээр түүнчлэн чиний бэлгийг устгахаар эрэлхийллээ.

8 Мөн чи бичээсүүдийг түүний гарт оруулсан учраас, болгоогтун, ёс бус хүмүүс тэдгээрийг чамаас холдуулан аваачаад байна.

9 Тиймийн тул, тийм ээ, ариун нандин болох тэдгээрийг чи ёс бус явдалд орууллаа.

10 Мөн, болгоогтун, бичигдсэн байхаар чиний болгосон, эсвээс орчуулсан, чиний гараас алдагдсан тэдгээр үгсийг өөрчлөхийг “Сатан тэдний зүрх сэтгэлд суулгаад байна.

11 Мөн болгоогтун, тэд үгсийг өөрчилсөн учир, чиний орчуулсан буюу бичигдсэн байхаар болгосноос тэдгээр нь эсэргээр уншигдана гэдгийг би чамд хэлж байна;

12 Мөн, энэ ухаанаар, энэ

ажлыг тэрээр устгаж болохын тул чөтгөр зальхай төлөвлөгөө боловсруулахаар эрэлхийллээ;

13 Учир нь тэрээр үүнийг хийлгэхээр тэдний зүрх сэтгэлд тавьсан билээ, ийнхүү худал хэлснээр, чамайг орчуулсан дүр эсгэж байна гэсэн үгэнд тэд чамайг “улайлган барилаа хэмээн тэд хэлж болно.

14 Үнэнээр, би чамд хэлнэ, Сатан энэ зүйлд хилэнцэт төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийг би хүлцэхгүй.

15 Учрыг болгоогтун, үүнийг дахин орчуулахыг асууснаар, чамайг Их Эзэн Бурханаа сориход хүргэхийн тулд үүнийг тэрээр тэдний зүрх сэтгэлд суулгаад байна.

16 Мөн тэгээд, болгоогтун, Бурхан түүнд орчуулах хүчийг өгсөн эсэхийг нь бид харъя—хэрэв тийм аваас, тэрээр мөн хүчийг түүнд дахин өгөх болно хэмээн тэд зүрх сэтгэлдээ хэлж мөн бодох ажгуу;

17 Мөн хэрэв Бурхан хүчийг түүнд дахин өгөх аваас, эсвэл хэрэв тэр дахин орчуулбал, эсвээс, өөрөөр хэлбэл, хэрэв тэрээр мөн нөгөөх үгсийг авчирваас, болгоогтун, мөн тэр нь бидэнд байгаа, мөн тэдгээрийг бид өөрчилсөн билээ;

18 Тиймийн тул тэд үл зөвшөөрнө, мөн тэрээр өөрийнхөө үгэнд худал хэлсэн, мөн түүнд бэлэг байхгүй, мөн

түүнд хүч байхгүй хэмээн бид хэлэх болно;

19 Тиймийн тул бид түүнийг, мөн тэр ажлыг ч бас устгах болно; мөн бид эцэст нь ичгүүргүй байхын тулд, мөн бид дэлхийн алдар сууг олж болохын тулд бид үүнийг хийх болно.

20 Үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, Сатан тэдний зүрх сэтгэлд нэн ихээр байршжээ; тэрээр сайн болох тэрхүү зүйлийн эсрэг “алдаст тэднийг”^б өдөөн хатгадаг буюу;

21 Мөн тэдний зүрх сэтгэл “ялзран доройтож, мөн”^б ёсон бус хийгээд жигшүүрт хэргүүдээр дүүрчээ; мөн тэд гэрлээс илүүгээр “харанхуйд” дурладаг, учир нь тэдний “явуулга хилэнцэт бөлгөө; тиймийн тул тэд надаас асуух нь үгүй.

22 Тэрээр тэдний сүнснүүдийг устгалд “хөтөлж болохын тулд”^б Сатан тэднийг өдөөн хатгадаг.

23 Мөн ийнхүү тэрээр Бурханы ажлыг устгахыг бодон, зальхай төлөвлөгөө боловсруулаад байна; гэвч би тэдний гараас үүнийг шаардах болно, мөн энэ нь тэднийг шившиглэж мөн “шүүлтийн өдөрт зэмлэл болон хувирна.

24 Тийм ээ, тэр энэ ажлын эсрэг тэдний зүрх сэтгэлийг хилэгнүүлэхээр өдөөн хатгаж байна.

25 Тийм ээ, тэрээр тэдэнд хандан: Та нар устгаж болохын тулд барьж авахаар отон хуурч, мэхлэн худал хэл; болгоогтун, энэ нь гэм хоргүй хэмээн хэлнэ. Мөн ийнхүү тэрээр тэднийг зусардан, мөн тэд хүнийг худал хэлсэнд нь барьж болохын тулд, тэд түүнийг устгаж болохын тулд, “худал хэлэх нь нүгэл биш хэмээн хэлдэг.

26 Мөн ийнхүү тэрээр тэднийг зусардан, мөн тэдний сүнснүүдийг “там уруу доош нь чирж оруулах хүртэл”^б хөтөлдөг; мөн ийнхүү тэрээр тэднийг “урхиндаа өөрсдийгөө барихаар болгодог.

27 Мөн ийнхүү тэрээр хүмүүний сүнсийг “устгахыг эрэлхийлэн, дэлхий дээр дээш доош, “ийш тийш холхидог буюу.

28 Үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, өөр нэг нь “мэхлэхийн тулд худал хэлдэг гэж боддогийн улмаас хууран мэхлэхийн тулд худал хэлдэг түүнд халаг, учир нь ийм нь Бурханы “шударга ёсноос чөлөөлөгдөхгүй.

20а су Нүгэл.

б 2 Ниф. 28:20–22.

21а С ба Г 112:23–24.

б су Ёс бус, Ёс бус байдал.

в Мозая 15:26.

су Сүнсний харанхуй.

г Мосе 5:13–18.

д Иохан 3:18–21;

С ба Г 29:45.

22а су Уруу татах, Уруу таталт.

б 2 Ниф. 2:17–18.

23а Хил. 8:25;

С ба Г 121:23–25.

25а 2 Ниф. 2:18; 28:8–9;

Алма 10:17; Мосе 4:4.

су Худал хэлэх.

26а су Там.

б су Урвалт.

в Сур. үгс 29:5–6;

1 Ниф. 14:3.

27а 2 Ниф. 28:19–23;

С ба Г 76:28–29.

б Иов 1:7.

28а су Заль, Залилах,

Залилан.

б Ром. 2:3.

су Шударга ёс.

29 Эдүгээ, болгоогтун, тэд эдгээр үгсийг өөрчилсөн байна, учир нь Сатан тэдэнд: Тэрээр та нарыг мэхэлжээ хэмээн хэлж, мөн тийнхүү тэмээр алдсыг үйлдүүлж, Их Эзэн Бурханыг чинь чамаар “сориулахын тулд тэднийг зусардаж байна.

30 Болгоогтун, гараас чинь алдагдсан тэдгээр үгсийг чи дахин бүү орчуул гэдгийг би чамд хэлж байна;

31 Учир нь, болгоогтун, тэдгээр үгсийн эсрэг худал хэлснээр тэд хилэнцэт төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх нь үгүй. Учир нь, болгоогтун, хэрэв чи яг адил үгсийг урагш авчрах аваас тэд чамайг худал хэллээ, мөн чи орчуулах дүр эсгэсэн боловч өөртэйгөө зөрчилдөж байна хэмээн хэлэх болно.

32 Мөн, болгоогтун, тэд үүнийг нийтлүүлэх болно, мөн Сатан чиний эсрэг хилэгнүүлэхээр тэднийг өдөөн хатгахын тулд тэдний зүрх сэтгэлийг хатууруулж тэгснээр тэд миний үгст үл итгэх болно.

33 Тийнхүү “Сатан уг ажил энэ үед ирэхгүй байж болохын тулд энэ үед орших чиний гэрчлэлийг ялан дийлэхийг бодож байна.

34 Гэвч болгоогтун, энд мэргэн ухаан буй, мөн “мэргэн

ухааныг би чамд үзүүлж, мөн эдгээр зүйлүүдийн талаар чи юу хийх ёстой тухай зарлигуудыг бибээр чамд өгч буй учир, чи орчуулах ажлаа дуустал үүнийг дэлхийд бүү үзүүл.

35 Энд мэргэн ухаан буй үүнийг дэлхийд бүү үзүүл хэмээн намайг чамд хэлсэнд бүү гайх—Учир нь чи хамгаалагдаж болохын тулд, үүнийг дэлхийд бүү үзүүл хэмээн би хэлсэн билээ.

36 Болгоогтун, үүнийг зөв шударга хүмүүст бүү үзүүл хэмээн би хэлээгүй байна;

37 Гэвч чи “зөв шударга хүмүүсийг ямагт үнэлэн шүүж эс чадах учир, эсвээс зөв шударга хүмүүсээс ёс бусчуудыг ямагт хэлж эс чадах учир, тиймийн тул, би чамд хэлнэ, уг асуудлын талаар бүх зүйлүүдийг дэлхийд мэдүүлэх нь зохимжтойг би харах хүртэл ^бдуугүй байгтун.

38 Мөн эдүгээ, үнэнээр би чамд хэлнэ, чиний бичсэн, гараас чинь алдагдсан тэдгээр “зүйлүүдийн шастир нь Нифайн ^бялтсууд дээр сийлбэрлэгдсэн буй;

39 Тийм ээ, Нифайн ялтсууд дээрх эдгээр зүйлүүдээс өөр нэг илүү тодорхой шастир өгөгдсөн тухай тэдгээр бичээсүүдэд өгүүлэгдсэн гэдгийг чи санагтун.

29a Мат. 4:7.

33a су Чөтгөр.

34a су Мэргэн ухаан.

37a Мат. 23:28.

б Ег. 14:14.

38a Мормоны Номны

анхны хэвлэлийн өмнөх үгэнд алдагдсан 116 хуудас материалыг Лихайн Ном хэмээн нэрлэгдсэн

ялтсуудын хэсгээс орчуулсан гэж Бошиглогч тайлбарлажээ. б су Ялтсууд.

40 Мөн эдүгээ, Нифайн ялтсууд дээр сийлбэрлэгдсэн тэрхүү шастир нь миний мэргэн ухаан дахь зүйлүүдэд онцгой хамаатайн учир, би энэ шастир дахь хүмүүсийн тухай мэдлэгийг авчрах болно —

41 Тиймийн тул, чи Нифайн “ялтсууд дээрх сийлбэрүүдийг, бүр доош хаан Бенжамины хаанчлалын үед ирэх хүртэл, эсвээс өөрийнхөө орчуулсан, өөртөө үлдээсэн тэр хэсэгт ирэх хүртэл орчуулах ёстой;

42 Мөн болгоогтун, чи үүнийг Нифайн цэдэг гэдгээр нь нийтлүүлэх болно; мөн ийнхүү миний үгсийг өөрчилсөн тэднийг би шившиглэнэ.

43 Тэд миний ажлыг устгахыг би зөвшөөрөхгүй; тийм ээ, миний мэргэн ухаан чөтгөрийн заль мэхээс илүү агуу гэдгийг би тэдэнд үзүүлэх болно.

44 Болгоогтун, тэд зөвхөн нэг хэсгийг л буюу Нифайн шастирын хураангуйллыг авсан болой.

45 Болгоогтун, миний сайн мэдээнд агуу санаануудыг өгч буй олон зүйл Нифайн ялтсууд дээр сийлбэрлэгдсэн байгаа; тиймийн тул, Нифайн сийлбэрүүдийн энэ эхний хэсгийг чи орчуулж, мөн энэ ажилд урагш ахих

ёстой нь надад буй мэргэн ухаан бөлгөө.

46 Мөн, болгоогтун, энэ “ажлын бүх үлдсэн хэсэг нь миний ариун бошиглогчид, тийм ээ, мөн тэрчлэн миний шавь нар, залбирлууддаа энэ хүмүүст урагш гарч ирэх ёстой хэмээн ⁶хүссэн миний “сайн мэдээний тэдгээр бүх хэсгүүдийг агуулдаг авай.

47 Мөн тэдний залбирлууд дахь “итгэлийнх нь дагуу энэ нь тэдэнд ⁶соёрхогдох болно гэдгийг би тэдэнд хэлсэн бөлгөө;

48 Тийм ээ, тэд өөрсдийнхөө өдрүүдэд номлож болохын тулд, тэдний ахан дүүс “леменчүүдэд, мөн түүнчлэн хагарал тэмцлийнхээ улмаас леменчүүд болсон тэд бүгдэд ирж болохын тулд тэдэнд миний өгсөн миний сайн мэдээ — тэдний итгэл байв.

49 Эдүгээ, энэ нь бүгд биш — тэдний залбирлууд дахь тэдний итгэл, хэрэв бусад үндэстнүүд энэ газар нутгийг эзэмших боломжтой аваас энэхүү сайн мэдээ тэрчлэн мэдүүлэгдэхийн тулд байв;

50 Мөн ийнхүү тэд залбирлууддаа, энэ газар нутагт энэ сайн мэдээнд итгэсэн хэн ч гэсэн мөнх амьдралыг авч болох нэгэн адислалыг энэ газар нутагт үлдээсэн бөлгөө;

51 Тийм ээ, энэ нь ямар ч

41a Мор. үгс 1:3–7.

46a су Мормоны Ном.

б Инос 1:12–18;

Морм. 8:24–26;

9:34–37.

в су Сайн мэдээ.

47a су Итгэл

б 3 Ниф. 5:13–15;

С ба Г 3:19–20.

48a Моро. 10:1–5;

С ба Г 109:65–66.

үндэстэн, ястан, хэлтэн буюу хүмүүст тэд хэн ч байлаа гэсэн, бүгдэд чөлөөтэй байх болно.

52 Мөн эдүгээ, болгоогтун, тэдний залбирлууд дахь тэдний итгэлийн дагуу би сайн мэдээнийхээ энэ хэсгийг өөрийнхөө хүмүүсийн мэдлэгт авчрах болно. Болгоогтун, тэдний хүлээн авсан тэрнийг би устгахаар бус, харин үүнийг өсгөн бэхжүүлэхээр авчирдаг.

53 Мөн энэхүү шалтгааны учир би хэлсэн билээ: Хэрэв энэ үеийнхэн зүрх сэтгэлээ эс хатууруулах аваас, би өөрийнхөө сүмийг тэдний дунд үндэслэн байгуулах болно.

54 Эдүгээ өөрийнхөө сүмийг устгахын тулд би үүнийг хэлдэггүй, харин өөрийнхөө сүмийг өсгөн бэхжүүлэхийн тулд би үүнийг хэлдэг;

55 Тиймийн тул, миний сүмд харьяалагдах хэн ч бай, “эмээх хэрэггүй, учир нь иймүүд нь тэнгэрийн ^бхаант улсыг ^вөвлөх болно.

56 Гэвч надаас үл ^аэмээж, бас зарлигуудыг минь ч эс дагаж, харин өөрсдөдөө ^башиг олохын тулд ^всүмүүдийг өсгөн бэхжүүлдэг, тийм ээ, мөн ёсон бусаар үйлдэж мөн чөтгөрийн хаант улсыг байгуулдаг тэд бол—тийм ээ, үнэнээр, үнэнээр, би та нарт

хэлнэ, миний түйвээх, мөн голдоо ортол чичрэн салгалахаар болгох тэд бол энэ буюу.

57 Болгоогтун, би бол Есүс Христ, Бурханы “Хүү. Би өөрийнхөндөө ирлээ, харин өөрийнхөн маань намайг хүлээн авсангүй.

58 Би бол харанхуйд гялалзагч “гэрэл билээ, мөн харанхуй нь үүнийг ойлгох нь үгүй.

59 Энэ сүргийнх бус “өөр ^бхонинууд надад бий хэмээн шавь нартаа хэлсэн тэр нь би билээ—мөн намайг үл ^войлгосон нь олон байв.

60 Мөн надад өөр хонинууд байсан мөн тэд болбоос Иаковын “угсааны мөчир байсан гэдгийг би энэ хүмүүст үзүүлнэм;

61 Мөн миний нэрээр тэдний хийсэн гайхамшигт ажлуудыг би гэрэлд авчрах болно;

62 Тийм ээ, тэдэнд тохинуулагдаж байсан өөрийнхөө сайн мэдээг би гэрэлд түүнчлэн авчрах болно, мөн болгоогтун, тэдгээр нь чиний хүлээн авсныг үгүйсгэх нь үгүй, харин тэдгээр нь үүнийг өсгөн бэхжүүлэх болно, мөн миний “сургаалын үнэн зөв хэсгүүдийг, тийм ээ, надад орших цорын ганц тэрхүү сургаалыг гэрэлд авчрах болно.

63 Мөн бибээр өөрийн сайн

55a су Айдас.

б су Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс.

в Мат. 5:10.

56a Ном. үгс 12:13–14.

б 4 Ниф. 1:26.

в су Чөтгөр—Чөтгөрийн сүм.

57a Ром 1:4.

58a С ба Г 6:21.

59a Иохан 10:16.

б су Сайн Хоньчин.

в 3 Ниф. 15:16–18.

60a су Их Эзэний талбай.

62a 3 Ниф. 11:31–40.

мэдээг бататгаж болохын тулд, өдий их сөргөлдөөн байхгүй байхын тулд үүнийг хийх бөлгөө; тийм ээ, “Сатан миний сургаалын хэсгүүдийн талаар хүмүүсийн зүрх сэтгэлийг ⁶зөрчилдөөнд өдөөн хатгадаг билээ; мөн эдгээр зүйлүүдэд тэд алдаа гаргадаг, учир нь тэд судруудыг ⁶гуйвуулж мөн тэдгээрийг ойлгох нь үгүй билээ.

64 Тиймийн тул, би энэ агуу нууцыг тэдэнд задлах болно;

65 Учир нь, болгоогтун, хэрэв тэд зүрх сэтгэлээ хатууруулахгүй аваас, тахиа дэгдээхийнүүдээ далавчин дороо цуглуулдаг шиг би тэднийг “цуглуулах болно;

66 Тийм ээ, хэрэв тэд ирэх аваас, тэд болно, мөн амьдралын “уснаас чөлөөтэй хүртэж болно.

67 Болгоогтун, энэ бол миний сургаал—наманчилж мөн надад “ирэх хэн ч болов, мөнхүү тэр нь миний ⁶сүм мөн.

68 Үүнээс илүүг буюу дутууг “тунхаглах хэн боловч мөн тэр нь надаас биш, харин миний ⁶эсрэг юм; тиймийн тул тэрээр миний сүмийнх биш.

69 Мөн эдүгээ, болгоогтун, миний сүмийнх, мөн эцсээ хүртэл тэвчдэг миний сүмийн хэнийг боловч, түүнийг би өөрийн “хадан дээр төлөвшүүлэх болно, мөн тамын ⁶үүд тэднийг дийлэх нь үгүй.

70 Мөн эдүгээ, дэлхийн амьдрал хийгээд “гэрэл, чиний Гэтэлгэгч, чиний ⁶Их Эзэн мөн чиний Бурхан болох түүний үгсийг санагтун. Амен.

ХЭСЭГ 11

1829 оны тавдугаар сард Пеннсильванийн Хармонид Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан түүний ах Хайрум Смитэд өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:39–46). Энэхүү илчлэлт нь Иосефын даруухан залбирал хийгээд хүсэлтийн хариу болж Урим ба Туммимаар дамжин хүлээн авагджээ. Энэхүү илчлэлт Аароны санваарыг сэргээсний дараа хүлээн авагдсаныг History of the Church-д өгүүлдэг.

1–6, Талбайд хөдөлмөрлөгсөд авралыг олох болно; 7–14, Мэргэн ухааныг эрэлхийлэгтүн, наманчлалыг тунхагла, Сүнсэнд

итгэ; 15–22, Зарлигуудыг сахь, мөн Их Эзэний үгсийг судал; 23–27, Илчлэлтийн хийгээд бошиглолын сүнсийг бүү үгүйсгэ;

63a су Чөтгөр.
б су Уруу тагалт.
в 2 Петр 3:16.

65a Лук 13:34;
3 Ниф. 10:4–6;
С ба Г 43:24.

66a су Амьдралын ус.

67a Мат. 11:28–30.
б су Есүс Христийн
Сүм.

68a 3 Ниф. 11:40.
б Лук 11:23.

69a су Хад.
б Мат. 16:18;

2 Ниф. 4:31–32;
С ба Г 17:8; 128:10.

70a су Гэрэл, Христийн
гэрэл.
б су Есүс Христ.

28–30, Христийг хүлээн авдаг тэд Бурханы хөвгүүд болдог.

АГУУ хийгээд “гайхамшигт Ажил хүмүүний үрсийн дунд тохиох гэж байна.

2 Болгоогтун, бибээр Бурхан билээ; амьд хийгээд “хүчирхэг, хоёр талдаа иртэй илднээс илүү ^бхурц, үе мөч болон чөмгийг аль алиныг нь хэдэн хэсэг болгон салгах миний ^үгэнд анхаарал тавигтун; тиймийн тул миний үгэнд анхаарал тавигтун.

3 Болгоогтун, “талбай нь цагаан хадахад бэлэн байна; тиймийн тул, тэрээр сүнснийхээ төлөө ^бүүрдийн авралыг Бурханы хаант улсад ^нөөцөлж болохын тулд хураахыг хүсэгч хэн боловч тэрээр хадуураараа чадлаараа хадаг мөн өдөр үргэлжилж байхад хурааг.

4 Тийм ээ, хадуураараа “хаждаж мөн хураах хэн боловч, мөн тэр нь Бурханаас дуудагддаг бөлгөө.

5 Тиймийн тул, чи надаас “асуух аваас чи хүлээж авах болно; хэрэв чи тогших аваас энэ нь чамд нээгдэх болно.

6 Эдүгээ, чи асуусан болохоор, болгоогтун, би чамд хэлж байна, миний зарлигуу-

дыг сахигтун, мөн “Сионы ашиг сонирхлыг авчирч мөн төлөвшүүлэхийг эрэлхийлэгтүн.

7 “Баялагуудыг бус харин ^бмэргэн ухааныг эрэлхийлэгтүн; мөн, болгоогтун, Бурханы нууцууд чамд нээгдэх болно, мөн тэгээд чи баян болгогдох болно. Болгоогтун, мөнх амьдралыг авагч тэр нь баян бөлгөө.

8 Үнэнээр, үнэнээр, би чамд хэлж байна, бүр чи надаас хүсэх аваас энэ нь чамд хийгдэх болно; мөн, хэрэв чи хүсэх аваас, чи энэ үед олон сайн зүйлийг хийх арга хэрэгсэл байх болно.

9 Энэ үеийнхэнд “наманчлалаас өөр юу ч бүү ^бярь. Миний зарлигуудыг сахигтун, мөн миний зарлигуудын “дагуу миний ажлыг урагшлуулахад тусал, мөн чи адислагдах болно.

10 Болгоогтун, чамд “бэлэг буй, эсвээс, хэрэв чи ^бүнэнч зүрх сэтгэлтэйгээр, Есүс Христийн сүр хүчинд, эсвээс чамд ярьдаг миний сүр хүчинд итгэн, итгэлд надаас хүсэх аваас, чамд бэлэг байх болно;

11 Учир нь, болгоогтун, ярьж буй тэр нь би бөлгөө;

11 1а Иса. 29:14;
С ба Г 4.
су Сайн мэдээний сэргээлт.
2а Алма 4:19; 31:5.
б Хил. 3:29–30;
С ба Г 6:2.
в Евр. 4:12.
г 1 Ниф. 15:23–25;
С ба Г 1:14; 84:43–45.

3а С ба Г 12:3.
б 1 Тим. 6:19.
в Лук 18:22; Хил. 5:8.
4а Илч. 14:15;
С ба Г 14:3–4.
5а су Залбирал.
6а Иса. 52:7–8;
С ба Г 66:11.
су Сион.
7а Хаад. дээд 3:11–13;

2 Ниф. 26:31;
Иаков 2:17–19;
С ба Г 38:39.
б су Мэргэн ухаан.
9а су Наманчлах,
Наманчлал.
б С ба Г 19:21–22.
в С ба Г 105:5.
10а С ба Г 46:8–12.
б Лук 8:15.

болгоогтун, би бол харанхуйд гялалзагч “гэрэл билээ, мөн би өөрийн ^бхүчээр эдгээр үгсийг чамд өгч байна.

12 Мөн эдүгээ, үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, сайныг үйлдэхэд—тийм ээ, шударгаар үйлдэхэд, “даруухнаар ^балхахад, зөв шударгаар ^вшүүхэд хөтөлдөг тэр ^сСүнсэнд ^дитгэлээ тавигтун; мөн энэ нь миний Сүнс бөлгөө.

13 Үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, “оюуныг чинь ^бтэгээрүүлж, сүнсийг чинь ^вбаяраар дүүргэх Сүнснээсээ би чамтай хуваалцах болно;

14 Мөн тэгээд чи мэдэх болно, эсвээс “зөв шударга ёсны зүйлүүдэд хамаарах юуг ч бай бүх зүйлийг чи хүлээж авна гэсэн итгэлээр итгэн чи надаас хүсвэл чи үүгээр мэдэх болно.

15 Болгоогтун, чи “дуудагдах хүртлээ номлохоор дуудагдсан гэж бодох хэрэггүй хэмээн би чамд зарлиглаж байна.

16 Миний сургаалын үнэнийг чи мэдэж болохын тулд, миний үгийг, миний “хадыг, миний сүмийг, мөн миний сайн мэдээг чи хүлээн

авах хүртлээ дахиад багахан хүлээгтүн.

17 Мөн тэгээд, болгоогтун, хүслүүдийн чинь дагуу, тийм ээ, бүр итгэлийн чинь дагуу энэ нь чамд хийгдэх болно.

18 Миний зарлигуудыг сахигтун; дуугүй бай; миний Сүнсэнд хандаж хүсэгтүн;

19 Яригдсан тэдгээр зүйлүүдийг тийм ээ, миний ажлын орчуулгыг гэрэлд авчрахад чи тусалж болохын тулд, тийм ээ, бүхий л зүрх сэтгэлээрээ надтай “нэгдэн нийлэгтүн; үүнийг гүйцээх хүртлээ чи тэвчээртэй бай.

20 Болгоогтун, бүх хүчин чадал, оюун, чадлаараа миний зарлигуудыг “сахих нь, тийм ээ, энэ нь чиний ажил бөлгөө.

21 Миний үгийг тунхаглахыг бүү эрэлхийл, харин эхлээд миний үгийг “олж авахыг эрэлхийл, мөн тэгвэл хэл чинь чөлөөтэй байх болно; тэгээд, хэрэв чи хүсэх аваас, миний Сүнс мөн миний үг, тийм ээ, хүмүүнийг итгүүлэх Бурханы хүч чамд байх болно.

22 Харин эдүгээ дуугүй бай; тийм ээ, энэ үе дэх хүмүүний үрст миний “өгөх тэр бүгдийг чи олж авах хүртлээ хүмүүний үрсийн дунд урагш од-

11a су Гэрэл, Христийн гэрэл.

б су Хүч.

12a су Даруу, Даруу байдал.

б су Алхах, Бурхантай хамт алхах.

в Мат. 7:1–5; Алма 41:14–15.

г Ром 8:1–9; 1 Иохан 4:1–6.

д С ба Г 84:116.

су Итгэл.

13a су Оюун.

б С ба Г 76:12.

в су Баяр баясгалан.

14a су Зөв шударга, Зөв шударга ёс.

15a ИТ 1:5.

су Эрх мэдэл; Дуудах, Бурханаас дуудагдах, Дуудлага.

16a С ба Г 6:34.

су Хад.

19a Иаков 6:5;

С ба Г 98:11.

20a су Дуулгавартай байх, Дуулгавартай, Дуулгавартай дагах.

21a Алма 17:2–3; С ба Г 84:85.

22a Алма 29:8.

сон ^бминий үгийг судал, мөн тэрчлэн хүмүүний үрсийн дунд урагш гарч ирэх ^вминий үгийг ^гсудал, эсвээс эдүгээ орчуулагдаж байгаа тэрнийг буюу, мөн тэгээд бүх зүйлс үүн дээр нэмэгдэх болно.

23 Болгоогтун, чи бол “Хайрум, хүү минь; Бурханы хаант улсыг ^бэрэлхийлэгтүн, мөн бүх зүйл шударга болох тэрний дагуу өгөгдөх болно.

24 Миний “сайн мэдээ болох миний хадан дээр ^ббаригтун;

25 “Илчлэлтийн сүнсийг, бас ^ббошиглолын сүнсийг бүү үгүйсгэ, учир нь эдгээр зүйлүүдийг үгүйсгэх түүнд халаг;

26 Тиймийн тул, чиний урагш одох тэр цаг нь миний

мэргэн ухаанд байх хүртэл зүрх сэтгэлдээ “нөөцлөгтүн.

27 Болгоогтун, сайн сайхан хүсэлтэй, мөн хураахын тулд хадуураараа “хадах тэд бүгдэд би ярьж байна.

28 Болгоогтун, би бол “Есүс Христ, Бурханы Хүү. Би бол дэлхийн амьдрал ба ^бгэрэл билээ.

29 Би бол өөрийнхөндөө ирсэн мөнхүү тэрбээр бөгөөд өөрийнхөн маань намайг хүлээн авсангүй;

30 Гэвч үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, намайг хүлээж авах болгонд, бүр миний нэрэнд итгэх тэдэнд Бурханы “хөвгүүд болох ^бхүчийг би тэдэнд өгөх болно. Амен.

ХЭСЭГ 12

1829 оны Тавдугаар сард Пеннсильванийн Хармонид Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Ахмад Иосеф Найтад өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:47–48). Мормоны Номын ялтсууд өөрт нь байгаа хийгээд тухайн үед ид дундаа явагдаж байсан орчуулгын ажлын талаар Иосеф Смитийн мэдэгдлүүдэд Иосеф Найт итгэсэн бөгөөд орчуулгыг үргэлжлүүлэх боломжийг тэдэнд олгосон эд материалын тусламжийг хэд хэдэн удаа Иосеф Смит болон түүний бичээчид үзүүлжээ. Иосеф Найтын хүсэлтээр Бошиглогч Их Эзэнээс асууж мөн энэхүү илчлэлтийг хүлээн авчээ.

1–6, Талбайд хөдөлмөрлөгсөд авралыг олох болно; 7–9, Хүссэн хийгээд тохирох болгон нь Их Эзэний ажилд тусалж болно.

“АГУУ хийгээд гайхамшигт Ажил хүмүүний үрсийн дунд тохиох гэж байна.

2 Болгоогтун, бибээр Бурхан

22б өх Библи.
в су Судрууд—
Судруудын үнэ
цэнэ.

г өх Мормоны Ном.

23а ИС—Т 1:4.

б Мат. 6:33.

24а су Сайн мэдээ.

б Мат. 7:24–27.

25а су Илчлэлт.

б Илч. 19:10.

су Бошиглох,

Бошиглол.

26а Дэд хууль 11:18;

С ба Г 6:20; 43:34;

ИС—А 1:37.

27а су Номлолын ажил.

28а су Есүс Христ.

б су Гэрэл, Христийн гэрэл.

30а су Бурханы

хөвгүүд охид.

б Иохан 1:12.

12 1а Мөн адил

харьцуулах

ишлэлийг

С ба Г 11:1-6-аас үз.

билээ; амьд хийгээд хүчирхэг, хоёр талдаа иртэй илднээс илүү хурц, үе мөч болон чөмгийг аль алиныг нь хэдэн хэсэг болгон салгах миний үгэнд анхаарал тавигтун, тиймийн тул миний үгэнд анхаарал тавигтун.

3 Болгоогтун, талбай нь цагаан хадахад бэлэн байна; тиймийн тул, тэрээр сүнснийхээ төлөө үүрдийн авралыг Бурханы хаант улсад нөөцөлж болохын тулд хураахыг хүсэгч хэн боловч тэрээр хадуураараа чадлаараа хадаг мөн өдөр үргэлжилж байхад хурааг.

4 Тийм ээ, хадуураараа хадаж мөн хураах хэн боловч, мөнхүү тэр нь Бурханаас дуудагддаг бөлгөө.

5 Тиймийн тул, чи надаас асуух аваас чи хүлээж авах болно; хэрэв чи тогших аваас энэ нь чамд нээгдэх болно.

6 Эдүгээ, чи асуусан болохоор, болгоогтун, би чамд хэлж байна, миний зарлигуудыг сахигтун, мөн Сионы ашиг сонирхлыг авчирч мөн төлөвшүүлэхийг эрэлхийлэгтүн.

7 Болгоогтун, чамд, мөн тэрчлэн энэ ажлыг урагш авчирч мөн төлөвшүүлэх хүсэлтэй бүх хүмүүст би ярьж байна;

8 Мөн өөрийнх нь анхаарал халамжинд итгэж даалгасан бүх зүйлд ^адаруу төлөв хийгээд ^бхайраар дүүрэн, ^витгэл, ^гнайдвар, мөн ^дэнэрэлтэй, биеэ барьдаг байхаас бусдаар өөр хэн ч энэ ажилд тусалж эс чадна.

9 Болгоогтун, эдгээр үгсийг ярих би бол дэлхийн гэрэл ба амьдрал, тиймийн тул бүх хүч чадлаараа сонсож дага, мөн тэгээд чи дуудагдах болно. Амен.

ХЭСЭГ 13

1829 оны тавдугаар сарын 15-нд Пеннсилвангийн Хармонийн ойролцоох Сасквиеханна голын эрэг дээр Иосеф Смит, Оливер Каудери хоёр Аароны санваарт томилогдсон томилолт оршвой (History of the Church, 1: 39–42). Уг томилолт нь Шинэ Гэрээнд Иохан Баптист хэмээн нэрлэгддэг тэрхүү Иохан хэмээн өөрийгөө танилцуулсан нэгэн тэнгэр элчийн гараар гүйцэтгэгдсэн бөлгөө. Мелкизедек санваар хэмээн нэрлэгддэг илүү өндөр санваарын түлхүүрүүдийг атгадаг эртний төлөөлөгчид Петр, Иаков, Иохан нарын удирдлагын дор ажиллаж байгаагаа тэрхүү тэнгэр элч тайлбарлажээ. Цаг нь болохоор Мелкизедек санваар тэдэнд олгогдох болно хэмээх амлалт Иосеф Оливер нарт өгөгджээ. (Хэсэг 27:7, 8, 12–ыг үз.)

8а су Даруу, Даруу
байдал.

б су Хайр.
в су Итгэл.

г су Найдвар.
д су Энэрэл.

Аароны санваарын түлхүүрүүд болон хүчнүүд толилуулагдав.

МИНИЙ нөхөд үйлчлэгч та нарт би Мессиагийн нэрээр, “тэнгэр элчүүдийн тохинууллын хийгээд ^бнаманчлалын сайн мэдээний, мөн нүглүүдийн ангижралын

тулд усанд умбуулалтаар хийх ^абаптисмын түлхүүрүүдийг атгагч ^аАароны санваарыг ^ахүртээж байна; мөн энэ нь ^вЛевийн хөвгүүд Их Эзэнд ^взөв шударга байдалд дахин өргөл өргөх хүртэл дэлхийгээс хэзээ ч дахин авагдахгүй байх болно.

ХЭСЭГ 14

1829 оны зургадугаар сард Нью-Йоркийн Фейеттэд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Давид Витмерт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:48–50). Витмерийн гэр бүл Мормоны Номын орчуулгыг нэн их сонирхож байлаа. Бошиглогч Ахмад Петр Витмерийн гэрт байрлаж, орчуулгын ажил дуусч, номын хэвлэлийн эрхийг баталгаатай болох хүртэл тэрээр энд амьдарч байв. Витмерийн хөвгүүдээс гурав нь уг ажлын жинхэнэ байдлын талаар тус бүрдээ гэрчлэл хүлээн авсан байсан хийгээд өөр өөрийнхөө үүргийн асуудалд гүнээ санаа тавих болов. Энэ болон түүний дараах хоёр илчлэлт нь (хэсэг 15 ба 16) Урим ба Туммимаар дамжуулан тавьсан асуултанд хариу болон өгөгдсөн ажгуу. Хожим нь Давид Витмер Мормоны Номын Гурван гэрчийн нэг болсон билээ.

1–6, Талбайд хөдөлмөрлөгсөд авралыг олно; 7–8, Мөнх амьдрал бол Бурханы бэлгүүдээс хамгийн агуу нь юм; 9–11, Христ тэнгэр болон дэлхийг бүтээжээ.

АГУУ хийгээд “гайхамшигт Ажил хүмүүний үрст тохиох гэж байна.

2 Болгоогтун, бибээр Бурхан билээ; амьд хийгээд хүчирхэг, хоёр талдаа иртэй илднээс

илүү хурц, үе мөч болон чөмгийг аль алиныг нь хэдэн хэсэг болгон салгах миний үгэнд анхаарал тавигтун, тиймийн тул миний үгэнд анхаарал тавигтун.

3 Болгоогтун, талбай нь цагаан хадахад бэлэн байна; тиймийн тул, тэрээр сүнснийхээ төлөө үүрдийн авралыг Бурханы хаант улсад нөөцөлж болохын тулд хураа-

13 1а су Тэнгэр элчүүд.
б су Наманчлах, Наманчлал.
в су Баптисм, Баптисм хүртээх.
г С ба Г 27:8; 84:18–34.
су Аароны санваар.
д ИС—Т 1:68–75.

су Томилох, Томилолт.
е Иосеф Смит—Түүхийн төгсгөлд Аароны санваарын сэргээлтийн талаар Оливер Каудерийн бичсэн шастирыг үз.

Дэд хууль 10:8; Шаст. дээд 6:48; С ба Г 128:24.
ё су Зөв шударга, Зөв шударга ёс.
14 1а С ба Г 11:1–6-аас үз.

хыг хүсэгч хэн боловч тэрээр хадуураараа чадлаараа хадаг мөн өдөр үргэлжилж байхад хурааг.

4 Тийм ээ, хадуураараа хадаж мөн хураах хэн боловч, мөн тэр нь Бурханаас дуудагддаг бөлгөө.

5 Тиймийн тул, чи надаас асуух аваас чи хүлээж авах болно; хэрэв чи тогших аваас энэ нь чамд нээгдэх болно.

6 Миний Сионыг урагш авчирч мөн төлөвшүүлэхийг эрэлхийлэгтүн. Бүх зүйлүүдэд миний зарлигуудыг сахигтун.

7 Мөн, хэрэв чи миний зарлигуудыг “сахьж мөн эцсээ хүртэл” тэвчих аваас, чи Бурханы бүх бэлгүүдээс хамгийн агуу бэлэг болох “мөнх амьдралтай” байх болно.

8 Мөнхүү улиран тохиох дор, хэрэв чи миний нэрээр, итгэлд итгэн Эцэгээс асуух

аваас, чи “сонсох мөн үзэх зүйлүүдийнхээ аль алиных нь талаар” гэрч болон зогсож болохын тулд, мөн тэрчлэн чи энэ үеийнхэнд наманчлалыг тунхаглаж болохын тулд үгийг өгдөг “Ариун Сүнсийг” чи хүлээн авах болно.

9 Болгоогтун, би бол тэнгэр хийгээд “дэлхийг” бүтээсэн, “амьд Бурханы” Хүү, “Есүс Христ”, “харанхуйд” нуугдаж эс чадах “гэрэл” билээ;

10 Иймийн тул, би өөрийн “бүрэн сайн мэдээг” “харийнханаас” Израилын угсаанд гарган авчрах ёстой.

11 Мөн болгоогтун, чи бол Давид, мөн чи туслахаар дуудагдсан болой; хэрэв чи уг зүйлийг хийж, мөн итгэлтэй байх аваас, сүнсний мөн биеийн талаар аль алианаар нь чи адислагдах болно, мөн шагнал чинь агуу байх бөлгөө. Амен.

ХЭСЭГ 15

1829 оны зургадугаар сард Нью-Йоркийн Фейеттэд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Жон Витмерт өгөгдсөн илчлэлт оривой (History of the Church, 1:50). (Хэсэг 14-ийн толгой гарчгийг үз.) Их Эзэнд зөвхөн өөрт нь болон Жон Витмерт мэдэгдсэн тэрхүү зүйлийн тухай ярьсан учраас уг захиас нь хувь хүний хувьд нэн ойр

<p>7а Лев. 26:3–12; Иохан 15:10; Мозая 2:22, 41; С ба Г 58:2. б су Тэвчих. в 2 Ниф. 31:20; С ба Г 6:13. су Мөнх амьдрал. 8а Мормоны Номны оршил хуудсан дахь Гурван Гэрчийн</p>	<p>гэрчлэлийг үз. б Мозая 18:8–10. су Гэрч. в су Ариун Сүнс. 9а Абр. 4:12, 24–25. б Иохан 1:1–3, 14; 3 Ниф. 9:15; С ба Г 45:1. су Бүтээх, Бүтээл. в Дан. 6:26; Алма 7:6; С ба Г 20:19</p>	<p>г Ром 1:4. д Мозая 4:2; С ба Г 76:20–24. е су Сүнсний харанхуй. ё 2 Сам. 22:29. су Гэрэл, Христийн гэрэл. 10а С ба Г 20:8–9; ИС—Г 1:34. б су Харийнхан.</p>
---	---	--

дотно мөн сэтгэлд хоногшим юм. Хожим нь Жон Витмер Мормоны Номын Найман Гэрчийн нэг болсон билээ.

1–2, Их Эзэний мутар бүх дэлхий дээр байна; 3–6, Сайн мэдээг номлох хийгээд бодгалиудыг аврах нь хамгийн үнэ цэнэтэй зүйл мөн.

АНХААРАГТУН, Миний Аүйлчлэгч Жон, мөн өөрийн Их Эзэн, мөн өөрийн Гэтэлгэгч, Есүс Христийн үгсийг анхаарагтун.

2 Учрыг болгоогтун, би чамд хурц тодорхойгоор мөн “хүчтэйгээр хэлж байна, учир нь миний мутар бүх дэлхий дээр байна.

3 Мөн зөвхөн чи бид хоёроос өөр хэн ч мэдэхгүй тэрнийг би чамд хэлэх болно —

4 Чамд хамгийн үнэ цэнэтэй тэр нь юу байж болохыг мэдэхийн тулд чи надаас олон удаа хүсч байсан билээ.

5 Болгоогтун, энэ зүйлийн төлөө мөн миний зарлигуудын дагуу чамд миний өгсөн үгсийг ярьсны төлөө чи адислагдсан болой.

6 Мөн эдүгээ, болгоогтун, би чамд хэлж байна, чамд хамгийн үнэ цэнэтэй байж болох тэр зүйл бол сүнснүүдийг надад авчирч болохын тулд, чи тэдэнтэй хамт миний “Эцэгийн” хаант улсад “амарч болохын тулд энэ хүмүүст наманчлалыг” тунхаглах явдал болой. Амен.

ХЭСЭГ 16

1829 оны зургадугаар сард Нью-Йоркийн Фейеттэд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Бага Петр Витмерт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:51). (Хэсэг 14-ийн толгой гарчгийг үз.) Бага Петр Витмер хожим нь Мормоны Номын Найман гэрчийн нэг болжээ.

1-2, Их Эзэний мутар бүх дэлхий дээр байна; 3-6, Сайн мэдээг номлох хийгээд бодгалиудыг аврах нь хамгаас үнэ цэнэтэй зүйл мөн.

АНХААРАГТУН, Миний Аүйлчлэгч Жон, мөн өөрийн Их Эзэн, мөн өөрийн

Гэтэлгэгч, Есүс Христийн үгсийг анхаарагтун.

2 Учрыг болгоогтун, би чамд хурц тодорхойгоор мөн хүчтэйгээр хэлж байна, учир нь миний мутар бүх дэлхий дээр байна.

3 Мөн зөвхөн чи бид хоёроос өөр хэн ч мэдэхгүй тэрнийг би чамд хэлэх болно —

15 2a Хил. 3:29–30.

су Хүч.

6a су Тэнгэр дэх Эцэг.

б су Бурханы хаант улс буюу Тэнгэр-

рийн хаант улс.

в су Амрах.

г су ба Г 18:15–16.

д су Номлолын ажил.

16 1a Мөн адил

харьцуулах

ишлэлийг

С ба Г 15:1-6-аас үз.

4 Чамд хамгийн үнэ цэнэтэй тэр нь юу байж болохыг мэдэхийн тулд чи надаас олон удаа хүсч байсан билээ.

5 Болгоогтун, энэ зүйлийн төлөө мөн миний зарлигуудын дагуу чамд миний өгсөн үгсийг ярьсны төлөө чи адислагдсан болой.

6 Мөн эдүгээ, болгоогтун, би чамд хэлж байна, чамд хамгийн үнэ цэнэтэй байж болох тэр зүйл бол сүнсийг надад авчирч болохын тулд, чи тэдэнтэй хамт миний Эцэгийн хаант улсад амарч болохын тулд энэ хүмүүст наманчлалыг тунхаглах явдал болой. Амен.

ХЭСЭГ 17

1829 оны зургадугаар сард Нью-Йоркийн Фейеттэд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Оливер Каудери, Давид Витмер болон Мартин Харрис нарт Мормоны Номын цэдгийг агуулсан сийлбэрлэгдсэн ялтсуудыг тэд үзэхийн өмнө өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:52–57). Онцгой гурван гэрч товлогдох болно гэдгийг Иосеф, түүний бичээч Оливер Каудери хоёр Мормоны Номын ялтсуудын орчуулганаас олж мэджээ (Ифер 5:2–4; 2 Нифай 11:3; 27:12-ыг үз). Оливер Каудери, Давид Витмер болон Мартин Харрис нар мөнөөх онцгой гурван гэрч байхаар сүнсээр урамшуулагдсан хүслээр хөтлөгдөв. Их Эзэнээс Бошиглогч асууж, мөн Урим ба Туммимаар дамжуулсан хариу болж энэхүү илчлэлт өгөгдсөн ажээ.

1–4, Гурван гэрч ялтсуудыг хийгээд бусад ариун нандин зүйлүүдийг итгэлээр үзэх болно; 5–9, Мормоны Номны бурханлиг чанарын талаар Христ гэрчилдэг.

БОЛГООГТУН, та нар миний үгэнд итгэх ёстой гэдгийг, хэрэв та нар зүрх сэтгэлийнхээ бүрэн зорилгоор ингэх аваас, та нар “ялтсуудыг, мөн тэрчлэн Лебений хуяг, ^билд, мөн уулан дээр

түүнийг Их Эзэнтэй “нүүр учран ярьж байхад нь Жаредын ‘ахад өгөгдсөн ^аУрим ба Туммим, мөн аглаг буйдад, ^вУлаан Тэнгисийн хөвөө хязгааруудад байхад нь Лихайд өгөгдсөн ^гшидэт зүг чиг заагчийг *үзэх болно.

2 Мөн итгэлээрээ, бүр эрт цагийн бошиглогчдод байсан тэр итгэлээр та нар тэдгээрийг үзэх болно.

3 Мөн та нар итгэлтэй болж

17 1а Морм. 6:6;
ИС—Т 1:52.
сү Ялтсууд.
б 1 Ниф. 4:8–9;
2 Ниф. 5:14;
Иаков 1:10;
Мозая 1:16.
в Эхл. 32:30; Ег. 33:11;

Моце 1:2
г Ифер 3:1–28.
д сү Урим ба
Туммим.
е 1 Ниф. 2:5.
ё 1 Ниф. 16:10, 16,
26–29;
Алма 37:38–47.

ж 2 Ниф. 27:12,
Ифер 5:2–4,
С ба Г 5:15.
Мормоны Номны
оршил хуудсан
дахь Гурван
гэрчийн
гэрчлэлийг мөн үз.

мөн тэдгээрийг нүдээрээ харсны дараа, та нар тэдгээрийн тухай Бурханы хүчээр “гэрчлэх болно;

4 Мөн миний үйлчлэгч Бага Иосеф Смит устгагдахгүй байж болохын тулд, бибээр энэ ажлаараа хүмүүний үрсийн төлөө зөв шударга зорилгуудаа хэрэгжүүлж болохын тулд та нар үүнийг хийх ёстой.

5 Мөн тэдгээрийг миний үйлчлэгч Бага Иосеф Смит харсан лугаа та нар харсан гэдгээ та нар гэрчлэх ёстой; учир нь, тэрээр тэдгээрийг харсан нь миний хүчээр болой, мөн энэ нь тэрээр итгэлтэй байсных бөлгөө.

6 Мөн тэрээр уг “номыг, бүр түүнд миний зарлигласан тэрхүү ^бхэсгийг орчуулсан

бөлгөө, мөн чиний Их Эзэн мөн чиний Бурхан амьдын адил энэ нь үнэн бөлгөө.

7 Иймийн тул, та нар түүний нэгэн адилаар мөн тэрхүү хүчийг, мөн тэрхүү итгэлийг, мөн тэрхүү бэлгийг хүлээн авлаа;

8 Мөн хэрэв та нарт өгсөн миний сүүлчийн зарлигуудыг та нар биелүүлэх аваас, тамын “үүд та нарыг дийлэх нь үгүй; учир нь миний ^бач ивээл та нарт хангалттай бөлгөө, мөн та нар эцсийн өдөр ^өөргөгдөх болно.

9 Мөн бибээр, Есүс Христ, та нарын “Их Эзэн мөн та нарын Бурхан, та нарт үүнийг бибээр зөв шударга зорилгуудаа хүмүүний үрст авчирч болохын тулд ярилаа. Амен.

ХЭСЭГ 18

1829 оны зургадугаар сард Нью-Йоркийн Фейеттэд Бошиглогч Иосеф Смит, Оливер Каудери, Давид Витмер нарт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:60–64). Аароны санваар олгогдох үед Мелкизедек санваар хүртээх тухай амлагдсан байв (хэсэг 13-ын толгой гарчгийг үз). Уг асуудлын талаарх мэдлэгийн төлөөх даруухан залбирлын хариуд Их Эзэн энэ илчлэлтийг өгчээ.

1–5, Сүмийг хэрхэн байгуулахыг судрууд үзүүлдэг; 6–8, Дэлхий алдаст боловсорч байна; 9–16, Бодгалуудын үнэ цэнэ агуу юм; 17–25, Авралыг олохын тулд хүмүүн өөр дээрээ Христийн нэрийг авах ёстой; 26–36, Арван-

хоёрын дуудлага хийгээд ажил үүрэг илчлэгдэв; 37–39, Оливер Каудери мөн Давид Витмер Арванхоёрыг эрж олох ёстой; 40–47, Авралыг олохын тулд хүмүүн наманчилж, баптисм хүртэж, мөн зарлигуудыг сахих ёстой.

3а су Гэрчлэх; Гэрч.
6а су Мормоны Ном.
б 2 Ниф. 27:22;
3 Ниф. 26:7–10.

8а Мат. 16:18;
3 Ниф. 11:39;
С ба Г 10:69.
б су Ач ивээл.

в 1 Ниф. 13:37;
3 Ниф. 27:14–15, 22;
С ба Г 9:14.
9а су Их Эзэн.

ЭДҮГЭЭ, болгоогтун, миний үйлчлэгч Оливер Каудери чи надаас мэдэхийг хүссэн тэр зүйлийн учир, би чамд эдгээр үгсийг өгч байна:

2 Болгоогтун, чиний бичсэн тэр зүйлүүд “үнэн гэдгийг олон тохиолдолд би Сүнсээрээ чамд илэрхийлсэн билээ; иймийн тул тэдгээрийг үнэн гэдгийг чи мэдэх бөлгөө.

3 Мөн хэрэв чи тэдгээрийг үнэн гэдгийг мэдэх аваас, болгоогтун, “бичигдсэн тэдгээр зүйлүүдэд чи итгэ хэмээх зарлигийг би чамд өгч байна;

4 Учир нь миний сүмийн суурь, миний “сайн мэдээ, мөн миний ^бхадны талаар бүх зүйлүүд тэдгээрт бичигдсэн буй.

5 Иймийн тул, хэрэв чи миний сайн мэдээ болон миний хадны суурин дээр миний сүмийг өсгөн бэхжүүлэх аваас, тамын үүд чамайг дийлэх нь үгүй.

6 Болгоогтун, “дэлхий алдаст боловсорч гүйцээд байна; мөн хүмүүний үрс, ^бхарийнхан хийгээд тэрчлэн Израилын угсаа аль аль нь наманчлалд өдөөн хатгагдах нь зайлшгүй шаардлагатай болой.

7 Иймийн тул, түүнд миний зарлигласны дагуу чи миний үйлчлэгч Бага Иосеф Смитийн гараар “баптисм хүртсэн учраас түүнд миний зарлигласан зүйлийг тэрээр биелүүлсэн билээ.

8 Мөн эдүгээ, надад мэдэгддэг тэрхүү зорилго болох өөрийн хувийн зорилгын тулд би түүнийг дуудсанд бүү гайх; иймийн тул, хэрэв тэрээр миний зарлигуудыг “сахихад ^бхичээнгүй байх аваас, тэрээр мөнх амьдралаар “адислагдах болно; мөн түүний нэр “Иосеф бөлгөө.

9 Мөн эдүгээ, Оливер Каудери, мөн тэрчлэн Давид Витмер та хоёрт би зарлигийн замаар ярьж байна; учир нь, болгоогтун, газар бүрийн бүх хүмүүнд би наманчлахыг зарлиглаж байна, мөн би та нарт өөрийн “төлөөлөгч Паулд ярьсан лугаа ярьж байна, учир нь та нар түүний дуудагдсантай адил дуудлагад дуудагдсан бөлгөө.

10 “Бодгалийн ^бүнэ цэнэ Бурханы мэлмийд агуу гэдгийг санагтун;

11 Учир нь, болгоогтун, Их Эзэн чиний “Гэтэлгэгч махан бодид ^бүхлийг амссан билээ; иймийн тул бүх хүмүүн наманчилж, мөн түүнд ирж

18 2a С ба Г 6:15–17.

3a С ба Г 98:11.

су Судрууд—
Судруудын үнэ
цэнэ.

4a су Сайн мэдээ.

б су Хад.

6a су Дэлхий.

б су Харийнхан.

7a ИС—Т 1:70–71.

8a су Дуулгавартай
байх, Дуулгавар-
тай, Дуулгавартай
дагах.

б су Хичээл зүтгэл.

в су Адислах,

Адислагдах,

Адислал.

г 2 Ниф. 3:14–15.

су Бага Иосеф
Смит

9a Ром 1:1.

10a су Бие.

б су Хүн—Бодгалийн
үнэ цэнэ.

11a су Гэтэлгэгч.

б су Цовдлуулалт.

болохын тулд бүх хүмүүний “зовлонг тэрээр биеэрээ” амссан бөлгөө.

12 Мөн тэрээр бүх хүмүүнийг өөртөө “наманчлалын нөхцөлд авчирч болохын тулд тэрээр нас барагсдаас дахин” босч ирсэн билээ.

13 Мөн наманчилдаг сүнсэнд түүний “баяр хөөр хичнээн агуу их билээ!

14 Иймийн тул, та нар энэ хүмүүст наманчлахыг “тунхаглахаар дуудагдсан болой.

15 Мөн, хэрэв та нар энэ хүмүүст наманчлалыг тунхаглахад өөрсдийн бүхий л өдрүүдэд хөдөлмөрлөж мөн зөвхөн нэг “бодгалийг надад авчрах аваас, миний Эцэгийн хаант улсад түүнтэй хамт та нарын баяр хөөр хичнээн агуу байх билээ!

16 Мөн эдүгээ, хэрэв миний Эцэгийн “хаант улсад надад авчирсан нэг бодгальтай хамт та нар агуу баяр хөөртэй байх аваас, хэрэв та нар олон бодгалийг надад” авчрах юм бол та нарын “баяр хөөр хичнээн агуу байх билээ!

17 Болгоогтун, миний сайн

мэдээ, мөн миний хад, мөн миний “аврал та нарт өмнө чинь байна.

18 Миний “нэрээр хүлээн авна хэмээх итгэлд итгэн та нар Эцэгээс” асуугтун, мөн хүмүүний үрст “зүйтэй бүх зүйлүүдийг илэрхийлэх Ариун Сүнс та нарт байх болно.

19 Мөн хэрэв та нарт “итгэл, “найджар, мөн “энэрэл байхгүй аваас, та нар юу ч хийж чадахгүй.

20 Тэр нь чөтгөрийн “сүм биш аваас, сүмийн эсрэг бүү” тэмц.

21 Христийн “нэрийг өөрсөд дээрээ авагтун, мөн үнэнийг” буурь суурьтайгаар “яригтун.

22 Мөн Есүс Христ болох миний нэрээр “баптисм хүртэж, мөн наманчилж мөн эцсээ хүртэл” тэвчих болгон нь, мөнхүү тэд нь аврагдах болно.

23 Болгоогтун, Есүс Христ бол Эцэгээс өгөгдсөн “нэр болой, мөн түүгээр хүмүүн аврагдаж болох өөр нэр өгөгдсөн нь үгүй;

24 Иймийн тул, Эцэгээс

11*в* Иса. 53:4–5.
су Цагаатгах,
Цагаатгал.

г су Гэтэлгэх,
Гэтэлгэгдэх,
Гэтэлгэл.

12*а* С ба Г 19:4–18.
су Наманчлах,
Наманчлал.

б су Амилуулалт.

13*а* Лук 15:7.

14*а* Алма 29:1–2;
С ба Г 34:5–6; 63:57.

15*а* су Хүн—Хүний
үнэ цэнэ.

16*а* су Бурханы хаант

улс буюу Тэнгэрийн хаант улс.

б су Номлолын ажил.

в Алма 26:11.
су Баяр баясгалан.

17*а* су Аврал.
18*а* Иохан 15:16.

б су Залбирал.
в С ба Г 88:63–65.

19*а* су Итгэл.
б су Найджар.

в су Энэрэл.

20*а* су Чөтгөр—
Чөтгөрийн сүм.

б 2 Тим. 2:23–24;

3 Ниф. 11:29–30.

21*а* 2 Ниф. 31:13;
Мозая 5:8;

3 Ниф. 27:5;
С ба Г 20:37.

б Ром 12:3.

в С ба Г 100:5–8.

22*а* су БAPTисм,
BAPTисм хүртээх.

б су Тэвчих.

23*а* Малах. 1:11;

Үйлс 4:12;

Мозая 3:17;

Хил. 3:28–29.

өгөгдсөн нэрийг бүх хүмүүн өөрсөд дээрээ авах ёстой, учир нь эцсийн өдөр тэд энэ нэрээр дуудагдах болно;

25 Иймийн тул, хэрэв тэд дуудагдах тэр “нэрээ мэдэхгүй бол, тэд миний Эцэгийн ^бхаант улсад байртай байж чадахгүй бөлгөө.

26 Мөн эдүгээ, болгоогтун, мөн “Харь хийгээд Иудей аль алинд нь миний сайн мэдээг тунхаглахаар дуудагдсан бусад нь буй.

27 Тийм ээ, бүр арванхоёр бөлгөө; мөн тэрхүү “Арванхоёр нь миний шавь нар байх болно, мөн тэд миний нэрийг өөрсөд дээрээ авах болно; мөн Арванхоёр нь зүрх сэтгэлийнхээ бүрэн зорилгоор миний ^бнэрийг өөрсөд дээрээ авахыг хүсэх тэд байх болно.

28 Мөн хэрэв тэд миний нэрийг зүрх сэтгэлийнхээ бүрэн зорилгоор өөрсөд дээрээ авахыг хүсэх аваас, тэд миний “сайн мэдээг ^бхүн болгонд номлохоор тэд бүх ^бдэлхий даяар явахын тулд дуудагдах болой.

29 Мөн тэд бол бичигдсэн тэр зүйлийн дагуу миний нэрээр “баптисм хүртээхээр надаас томилогдсон тэд болой;

30 Мөн бичигдсэн тэр нь та

нарын өмнө та нарт байна; иймийн тул, та нар бичигдсэн үгсийн дагуу үүнийг гүйцэтгэх ёстой.

31 Мөн эдүгээ “Арванхоёр, та нарт би хэлж байна — Болгоогтун, миний ач ивээл та нарт хангалттай бөлгөө; та нар миний өмнө цэх шулуун алхах ёстой мөн нүгэл бүү үйлд.

32 Мөн, болгоогтун, та нар бол хүмүүнд Бурханы өгсөн “дуудлагууд хийгээд бэлгүүдийн дагуу, та нарт байгаа Ариун Сүнсний хүчний ^бдагуу миний сайн мэдээг тунхаглахаар, санваартнууд хийгээд багш нарыг та нар надаас “томилохын тулд томилогддог тэд болой;

33 Мөн бибээр Есүс Христ, та нарын Их Эзэн мөн та нарын Бурхан, үүнийг ярилаа.

34 Эдгээр “үгс нь хүмүүсийнх буюу хүнийх биш, харин минийх бөлгөө; иймийн тул, тэдгээр нь хүнийх биш, харин минийх гэдгийг та нар гэрчлэх ёстой;

35 Учир нь тэдгээрийг та нарт ярьсан нь миний “дуу хоолой болой; учир нь миний Сүнсээр та нарт тэдгээр нь өгөгдсөн авай, мөн миний хүчээр та нар тэдгээрийг бие биендээ уншиж өгч болох

25a Мозая 5:9–14.

б су Селестиел алдар суу.

26a С ба Г 90:8–9; 112:4.

27a су Төлөөлөгч.

б С ба Г 27:12.

28a су Сайн мэдээ.

б С ба Г 1:2; 42:58.

в Марк 16:15–16.

29a 3 Ниф. 11:21–28;

С ба Г 20:72–74.

31a С ба Г 107:23–35.

32a С ба Г 20:27.

б 2 Петр 1:21;

С ба Г 68:3–4.

в Моро. 3:1–4;

С ба Г 20:60; 107:58.

су Томилох, Томилолт.

34a су Судрууд.

35a С ба Г 1:38.

су Дуу хоолой.

бөлгөө; мөн миний хүчээр биш байсан аваас, та нарт тэдгээр нь байж чадахгүй байсан буюу;

36 Иймийн тул, миний дуу хоолойг сонссоноо, мөн миний үгийг мэднэ гэдгээ та нар “гэрчилж чадна.

37 Мөн эдүгээ, болгоогтун, миний ярьсан тэдгээр хүслүүдтэй байх Арванхоёрыг та нар эрж олохыг би Оливер Каудери чамд, мөн тэрчлэн Давид Витмерт даалгаж байна;

38 Мөн тэдний хүслүүдээр мөн тэдний “ажлуудаар та нар тэднийг мэдэх болно.

39 Мөн та нар тэднийг олсон үедээ та нар эдгээр зүйлүүдийг тэдэнд үзүүлэх ёстой.

40 Мөн та нар доош сөхөрч мөн миний нэрээр Эцэгийг “бишрэн шүтэх ёстой.

41 Мөн та нар дэлхийд: Та нар наманчилж мөн Есүс Христийн нэрээр баптисм хүртэх ёстой хэмээн номлох ёстой;

42 Учир нь бүх хүмүүс мөн зөвхөн эрчүүд төдийгүй

эмэгтэйчүүд мөн “хариуцлага хүлээх насанд хүрсэн хүүхдүүд наманчилж мөн баптисм хүртэх ёстой.

43 Мөн эдүгээ, та нар үүнийг хүлээж авсны дараа, та нар миний “зарлигуудыг бүх зүйлүүдэд сахих ёстой;

44 Мөн тэд наманчлалд ирж болохын тулд мөн тэд миний Эцэгийн хаант улсад ирж болохын тулд тэдний олон нүглийн талаар “итгүүлэхээр би та нарын гараар хүмүүний үрсийн дунд “гайхамшигт ажлыг үйлдэх болно.

45 Иймийн тул, та нарт миний өгдөг адислалууд бүх зүйлээс илүү “дээгүүр болой.

46 Мөн та нар үүнийг хүлээн авсны дараа, хэрэв та нар миний зарлигуудыг эс “сахих аваас, та нар миний Эцэгийн хаант улсад аврагдаж чадах нь үгүй.

47 Болгоогтун, бибээр Есүс Христ, та нарын Их Эзэн, мөн та нарын Бурхан, мөн та нарын Гэтэлгэгч, Сүнснийхээ хүчээр үүнийг ярилаа. Амен.

ХЭСЭГ 19

1830 оны гуравдугаар сард Нью-Йоркийн Манчестерт Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:72–74). Бошиглогч өөрийн түүхэнд үүнийг “хүнийх бус, харин Мөнх болох түүгээр Мартин Харрист өгөгдсөн Бурханы зарлиг” хэмээн танилцуулжээ (History of the Church, 1:72).

36a су Гэрчлэх.
38a су Ажлууд.
40a су Шүтэн бишрэх.
42a С ба Г 20:71;
29:47; 68:27.
су Хариуцах,

Хариуцлага,
Хариуцлагатай.
43a су Бурханы зарлигууд.
44a Алма 36:12–19;
62:45.

б Иса. 29:14;
С ба Г 4:1.
45a С ба Г 84:35–38.
46a С ба Г 82:3.

1–3, Христэд бүх хүч буй; 4–5, Бүх хүмүүн наманчлах буюу эсвээс зовох ёстой; 6–12, Мөнхийн шийтгэл бол Бурханы шийтгэл болой; 13–20, Хэрэв тэд наманчлбаас, тэд зовогүй байж болохын тулд Христ бүхний төлөө зовсон юм; 21–28, Наманчлалын сайн мэдээг номлогтун; 29–41, Баярт мэдээг тунхаглагтун.

БИ бол “Альфа ба Омега, ^бИх Эзэн Христ бөлгөө; тийм ээ, бүр би бол эхлэл ба төгсгөл, дэлхийн Гэтэлгэгч тэрбээр бөлгөө.

2 Би бүх зүйлийг өөртөө “захируулж болохын тулд би түүнийх болох Эцэгийн, миний талаарх тааллыг бибээр биелүүлж мөн ^бдуусган — үүнийг гүйцэлдүүлээ —

3 Бүр Сатан болон түүний ажлуудыг дэлхийн “төгсгөлд ^бустгах мөн түүний оршин суугчид дээр миний тохиолгох шүүлтийн тэрхүү агуу эцсийн өдөр, хүн бүрийг хийсэн ^аажлууд хийгээд үйлүүдийнх нь дагуу ^шшүүх бүх ^ссүр хүчийг өөртөө үлдээсэн буюу.

4 Мөн хүн бүр “наманчлах буюу эсвээс ^бзовох нь гарцаа-

гүй, учир нь бибээр, Бурхан, “төгсгөлгүй бөлгөө.

5 Иймийн тул, би өөрийн тохиолгох тэрхүү шүүлтүүдийг “цуцлах нь үгүй, харин тийм ээ, миний ^бзүүн гар талд олдох тэдэнд уйлаан, “ёолон гаслах, мөн шүдээ хавирах, гаслах нь тохиох болно.

6 Гэсэн хэдий ч, энэхүү тарчлалд төгсгөл үгүй байх болно хэмээн “бичигдсэн нь үгүй, гэвч энэ нь ^бтөгсгөлгүй тарчлал хэмээн бичигдсэн ажгуу.

7 Дахин, энэ нь “*мөнхийн ял* хэмээн бичигдсэн болой; иймийн тул энэ нь бүхэлдээ миний нэрийн алдар суугийн тулд, хүмүүний үрсийн зүрх сэтгэлд нөлөөлж болохын тулд энэ нь бусад судруудаас илүү тодорхой юм.

8 Иймийн тул, энэ нууцыг би чамд тайлбарлах болно, учир нь энэ нь миний төлөөлөгчдөд мэдэгдсэний адилаар чамд мэдэгдвээс зохилтой.

9 Энэ зүйлийн талаар, та нар миний “амралтад орж болохын тулд энэ зүйлд сонгогдсон та нарт бүр нэг мэтээр би ярьж байна.

10 Учир нь, болгоогтун,

19 1а Илч. 1:8, 11;
3 Ниф. 9:18;
С ба Г 35:1; 61:1.
су Альфа ба Омега.
б су Есүс Христ.
2а Филип. 3:21.
б Иохан 17:4;
3 Ниф. 11:11.
3а су Дэлхий—
Дэлхийн төгсгөл.

б Иса. 14:12–17;
1 Иохан 3:8;
1 Ниф. 22:26;
С ба Г 88:111–115.
в су Ажлууд.
г су Эцсийн шүүлт.
д су Хүч.
4а су Наманчлах,
Наманчлал.
б Лук 13:3; Хил. 14:19.

в Моце 1:3.
5а С ба Г 56:4; 58:32.
б Мат. 25:41–43.
в Мат. 13:42.
6а С ба Г 76:105–106;
138:59.
б С ба Г 76:33, 44–45.
7а Хил. 12:25–26;
С ба Г 29:44.
9а су Амрах.

бурханлиг чанарын “нууц хичнээн агуу билээ! Учир нь, болгоогтун, би төгсгөлгүй билээ, мөн миний гараас өгөгддөг тэрхүү шийтгэл төгсгөлгүй шийтгэл байдаг, учир нь ⁶Төгсгөлгүй нь миний нэр бөлгөө. Иймийн тул—

11 “Мөнхийн шийтгэл бол Бурханы шийтгэл авай.

12 Төгсгөлгүй шийтгэл бол Бурханы шийтгэл болой.

13 Иймийн тул, наманчлахыг, мөн миний үйлчлэгч Бага Иосеф Смитийн гараар миний нэрээр хүлээж авах “зарлигуудыг сахихыг би чамд зарлиглаж байна;

14 Мөн тэдгээрийг чи хүлээн авсан нь миний бүхнийг чадагч сүр хүчээр болой.

15 Тиймийн тул би чамд наманчлахыг зарлиглаж байна—наманчил, эс тэгвээс би чамайг амныхаа үгэн саваагаар, мөн хилэгнэлээрээ, мөн уураараа арчин хаях болно, мөн чиний “зовлон гашуун байх болно—хэр зэрэг гашууныг чи мэдэх нь үгүй, хэр зэрэг хүчтэйг чи мэдэх нь үгүй, тийм ээ, тэвчихэд хэр зэрэг хэцүүг чи мэдэх нь үгүй.

16 Учрыг болгоогтун, хэрэв тэд “наманчлах аваас, тэд

⁶зовохгүй байж болохын тулд Бурхан, бибээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг “амссан билээ;

17 Гэвч хэрэв тэд үл наманчлах аваас, бүр миний адилаар тэд “зовох ёстой;

18 Бүр бүхнээс хамгийн агуу Бурхан намайг өвдөхийн улмаас дагжин чичрэх, мөн сүв бүрээс цус шүүрэх, мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовоход хүргэсэн тэрхүү зовлон нь—мөн намайг тэрхүү гашуун аяганаас “уухгүй, мөн айснаас эргэн буцахад хүргэж болохоор байсан билээ—

19 Гэсэн хэдий ч, алдар суу нь Эцэгт байх болтугай, мөн бибээр хүртэж мөн хүмүүний үрсийн төлөө өөрийн бэлтгэлүүдийг “дуусгасан билээ.

20 Иймийн тул, би чамд наманчлахыг дахин зарлиглаж байна, эс тэгвээс би өөрийн бүхнийг чадагч сүр хүчээр чамайг даруусгана; мөн тийн чи нүглүүдээ “хүлээх авай, эс тэгвээс хамгийн багадаа л, тийм ээ, намайг Сүнсээ татан авах тэр цагт чиний хамгийн бага хэмжээгээр амссан миний ярьсан эдгээр шийтгэлүүдийг чи амсах болно.

21 Мөн наманчлалаас өө-

10a Иаков 4:8;
С ба Г 76:114–116.

б Моце 1:3; 7:35.
су Төгсгөлгүй.

11a Мат. 25:46.

13a С ба Г 5:2; 10:6–7;
17:1–9.

15a Алма 36:11–19.

16a су Нүглүүдийн
ангжрал.

б Су Нигүүлсэнгүй,
Нигүүлсэл.

в Алма 11:40–41.

су Цагаатгах,
Цагаатгал.

17a С ба Г 29:17.

18a Лук 22:42–44.

19a Иохан 17:4; 19:30.

20a Тоол. 5:6–7;
Мозая 26:29;
С ба Г 58:43; 64:7.

су Хүлээн
зөвшөөрөх, Хүлээн
зөвшөөрөлт.

рийг чи “номлох ёсгүй хэмээн би зарлиглаж байна, мөн энэ нь надад орших мэргэн ухаан болтол эдгээр зүйлүүдийг дэлхийд ^ббүү үзүүл.

22 Учир нь эдүгээ тэд бор хоол “идэж чадах нь үгүй, харин тэд ^бсүү хүлээж авах ёстой; иймийн тул, эдгээр зүйлүүдийг тэд мэдэх ёсгүй, эс тэгвээс тэд мөхнө.

23 Надаас сурагтун, мөн миний үгсийг анхаарагтун; миний Сүнсний “номхон дөлгөөн байдалд ^балхагтун, мөн надаар дамжин “амар амгалан чамд байх болно.

24 Би бол “Есүс Христ; би Эцэгийн тааллаар ирсэн билээ, мөн түүний тааллыг би хэрэгжүүлдэг.

25 Мөн дахин, чи хөршийнхөө “эхнэрт ^бшунах ёсгүйг би чамд зарлиглаж байна; мөн хөршийнхөө амийг бүү эрэлхийл.

26 Мөн дахин, чи өөрийнхөө өмч хөрөнгөнд харамч шунаг байх ёсгүйг, харин “үнэнийг хийгээд Бурханы үгийг агуулагч Мормоны Номыг хэвлэхэд үүнийг харамгүйгээр хуваалцахыг би чамд зарлиглаж байна —

27 Энэ нь “Харьд хэлэх миний үг болой, тэд сайн мэдээнд итгэж, мөн аль хэдийн ирчихсэн ^бМессиаг ирнэ хэмээн хүлээхгүй байж болохын тулд энэ нь “Иудей, тэдний ‘үлдэгдэл болох леменчүүдэд удалгүй очиж болох бөлгөө.

28 Мөн дахин, чи “чангаар хийгээд түүнчлэн зүрх сэтгэлдээ; тийм ээ, дэлхийн өмнө хийгээд нам чимээгүй, олны дунд хийгээд мөн түүнчлэн ганцаархнаа ^бзалбирах ёстой хэмээн би чамд зарлиглаж байна.

29 Мөн чи баярт мэдээг “тунхаглах ёстой, тийм ээ, үүнийг уулсын дээр, мөн өндөр газар болгонд, мөн уулзах нь чамд зөвшөөрөгдсөн бүх хүмүүсийн дунд зарлан тунхаглагтун.

30 Мөн чи үүнийг бүхий л даруу байдлаар надад “итгэж найдан, хорт муу үгээр яригчдын өөдөөс хорт муу үгээр ярихгүйгээр үйлдэх ёстой.

31 Мөн “шашны сургаалын талаар чи бүү ярь, харин чи наманчлал хийгээд Аврагчид итгэх ^битгэл, мөн ^ббаптисмаар хийгээд ‘галаар,

21а С ба Г 11:9.

б ИС—Т 1:42.

22а С ба Г 78:17–18.

б Евр. 5:11–14;

С ба Г 50:40.

23а су Номхон дөлгөөн, Номхон дөлгөөн байдал.

б Моро. 7:3–4.

в су Амар амгалан.

24а су Есүс Христ.

25а Ег. 20:17;

1 Кор. 7:2–4.

су Завхайрал.

б су Шунах.

26а су Үнэн.

27а су Харийнхан.

б су Мессиа.

в су Иудейчүүд.

г Омнаи 1:14–19;

Мозая 25:2–4;

Хил. 8:21;

3 Ниф. 2:12–16.

28а С ба Г 20:47, 51; 23:6.

б 1 Тим. 2:8.

су Залбирал.

29а су Номлолын ажил.

30а су Итгэл.

31а 2 Тим. 2:23–24.

б су Итгэл.

в су Баптисм,

Баптисм хүртээх.

г Мат. 3:11.

тийм ээ, бүр ^аАриун Сүнсээр ирэх нүглүүдийн “ангигжралыг тунхаглах ёстой.

32 Болгоогтун, энэ бол уг асуудлаар чамд миний өгөх агуу хийгээд сүүлчийн “зарлиг болой; учир нь энэ нь чиний өдөр тутмын алхаанд, бүр амьдралын чинь эцэс хүртэл хангалттай байх болно.

33 Мөн хэрэв чи эдгээр “зөвлөгөөг үл тоомсорлох аваас, зовлонг чи хүлээн авах болно, тийм ээ, бүр чамд өөрт чинь болон өмч хөрөнгөнд чинь устгал тохиох болно.

34 Өмч хөрөнгийнхөө нэг хэсгийг, тийм ээ, бүр газрынхаа нэг хэсгийг, мөн гэр бүлээ тэтгэхээс бусад бүхнийг “зар.

35 Хэвлэгчтэй “гэрээлсэн ^бөрөө төл. “Боолчлолоос өөрийгөө чөлөөлөгтүн.

36 Чи гэрийнхэнтэйгээ уулзахыг хүсэхээс бусдаар гэр болон гэр орноо “орхи.

37 Мөн бүгдэд чөлөөтэйгөөр “яригтун; тийм ээ, Хосанна, хосанна, Их Эзэн Бурханы нэр адислагдаг хэмээн чанга дуу хоолойгоор, баяслын дуугаар чангаар тунхаглан—бүр ^бүнэнийг номло, ухуул, мөн тунхагла!

38 Ямагт “залбирагтун, мөн бибээр Сүнсээ чиний дээр ^бцутгах болно—тийм ээ, чиний олж авч болох, ялзран устах дэлхийн баялгууд хийгээд тэдгээрийн ач холбогдлоос адислал чинь бүр илүү агуу байх болно.

39 Болгоогтун, чи үүнийг баясал хийгээд зүрх сэтгэлээ баяр хөөрт өргөлгүйгээр уншиж чадна гэж үү?

40 Эсвээс чи сохор хөтөч атлаа нэг газраас нөгөөд удаан аялж чадна гэж үү?

41 Эсвээс чи “даруу мөн номхон дөлгөөн байж, миний өмнө өөрийгөө ухаалгаар авч явж чадна гэж үү? Тийм ээ, өөрийнхөө Аврагч надад ^бирэгтүн. Амен.

ХЭСЭГ 20

1830 оны дөрөвдүгээр сард Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Сүмийн зохион байгуулалт ба удирдлагын талаар өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:64–70). Энэ илчлэлтийн талаарх түүний цэдгийн оршил болгон Бошиглогч бичихдээ, “Бошиглогчдын хийгээд илчлэлтийн сүнсээр бид Түүнээс (Есүс Христ) дараах зүй-

31d су Ариун Сүнсний бэлэг.
e су Нүглүүдийн ангигжрал.
32a С ба Г 58:26–29.
33a су Бурханы зарлигууд.
34a Үйлс 4:34–35.
35a ө.х. Мормоны

Номны анхны хэвлэлийг гаргахад төлөх.
б су Өр.
в Сур. үгс 22:7.
36a Мат. 19:29.
37a С ба Г 58:47;
68:8; 71:7.
б С ба Г 75:4.

38a Лук 18:1;
2 Ниф. 32:9;
С ба Г 10:5.
б Сур. үгс 1:23;
Үйлс 2:17.
41a су Даруу, Даруу байдал.
б Мат. 11:28–30.

лийг олж мэдсэн бөлгөө; энэ нь бидэнд зөвхөн их мэдээлэл өгсөн төдийгүй, харин Түүний таалал хийгээд зарлигийн дагуу яг хэдний өдөр бид Түүний Сүмийг дэлхий дээр дахин зохион байгуулах ёстойг бидэнд бас зааж өгсөн юм” гэжээ (History of the Church, 1:64).

1–16, Мормоны Ном хожмын үеийн ажлын бурханлиг чанарыг нотолдог; 17–28, Бүтээлт, уналт, цагаатгал, мөн баптисмын сургаалууд нотлогдов; 29–37, Наманчлал, зөвтгөл, ариусал, мөн баптисмыг удирдагч хуулиуд толилуулагдав; 38–67, Ахлагчид, санваартнууд, багш нар, мөн диконы үүргүүд хураангуйлан томъёологдов; 68–74, Гишүүдийн үүргүүд, хүүхдийн адислал, мөн баптисмын маяг илчлэгдэв; 75–84, Ариун ёслолын залбирлууд хийгээд Сүмийн гишүүнчлэлийг чиглүүлэгч дүрмүүд өгөгдөв.

ЭДГЭЭР эцсийн өдрүүдэд Христийн “Сүм” бөндийн боссон нь бидний Их Эзэн Аврагч Есүс Христ махан бодид ирснээс хойш нэг мянга найман зуу мөн гучин жил болжээ, энэ нь манай орны хуулиудад нийцэн, зүй ёсоор Бурханы хүсэл зориг хийгээд зарлигуудаар дөрөв дэх сард, мөн Апрель хэмээн нэрлэгддэг энэ сарын зургаа дахь өдөр “зохион байгуулагдаж мөн үндэслэгдсэн бөлгөө —

2 Бурханаас “дуудагдаж, мөн

Есүс Христийн “төлөөлөгч, энэ сүмийн анхны “ахлагч байхаар томилогдсон Бага Иосеф Смитэд өгөгдсөн зарлигууд нь эдгээр болой;

3 Мөн тэрчлэн Бурханаас дуудагдсан, Есүс Христийн төлөөлөгч, энэ сүмийн хоёр дахь ахлагч байхаар түүний гарын дор томилогдсон Оливер Каудерид буюу;

4 Мөн энэ нь бидний Их Эзэн ба Аврагч Есүс Христийн ач ивээлийн дагуу болой, түүнд бүх алдар суу эдүгээ болон үүрд аль алинд нь байх болтугай. Амен.

5 Тэрбээр нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авсан нь энэхүү анхны ахлагчид жинхэнээр үзүүлэгдсэний дараа, тэрээр дэлхийн хоосон зүйлүүдэд дахин “орооцолдсон байлаа;

6 Гэвч итгэлээр дамжуулан наманчилж, өөрийгөө чин сэтгэлээсээ даруусгасны дараа, “дүр төрх нь цахилгаан мэт, өмсгөл нь бусад бүх цагаанаас илт цагаан, цэв цэвэрхэн нэгэн ариун “тэнгэр элчээр Бурхан түүнд тохиуулсан авай;

20 1a 3 Ниф. 27:1–8.
су Сүмийн нэр;
Есүс Христийн
Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн
Сүм.

б ИС—Т 1:2.
в С ба Г 21:3.
2a су Эрх мэдэл;
Дуудах, Бурханаас
дуудагдах,
Дуудлага.

б су Төлөөлөгч.
в су Ахлагч.
5a ИС—Т 1:28–29.
6a Мат. 28:2–3.
б ИС—Т 1:30–35.
су Тэнгэр элчүүд.

7 Мөн түүнд бурханлигаар нөлөөлсөн зарлигуудыг түүнд өгсөн буюу;

8 Мөн өмнө нь бэлтгэгдсэн “аргаар Мормоны Номыг орчуулах хүчийг дээрээс түүнд өгсөн бөлгөө;

9 Энэ нь унасан хүмүүсийн цэдгийг хийгээд харийнханд болон тэрчлэн иудейчүүдэд очих ёстой Есүс Христийн “сайн мэдээний” бүрэн байдлыг агуулдаг;

10 Энэ нь бурханлиг нөлөөллөөр өгөгдөж, мөн тэнгэр элчүүдийн тохинууллаар “бусдад батлагдан, мөн тэднээр дэлхийд тунхаглагддаг авай—

11 Ариун судрууд “үнэн гэдгийг, мөн Бурхан хүмүүнд бурханлигаар нөлөөлж, энэ эрин зуун хийгээд эрт дээр үеийн адил тэднийг өөрийн ариун ажилд дууддагийг дэлхийд нотолдог болой;

12 Үүгээр тэрбээр өчигдөр, өнөөдөр, мөн үүрд нэг л “адил Бурхан гэдгийг харуулдаг. Амен.

13 Тиймийн тул, ийнхүү агуу гэрчүүдтэй байснаар дэлхий, бүр үүнээс хойш энэ ажлын

мэдлэгт ирэх болгон нь тэднээр шүүгдэх болно.

14 Мөн үүнийг итгэлд хүлээн авах мөн “зөв шударгаар ажиллах тэд мөнх амьдралын титмийг хүлээн авах болно;

15 Гэвч “итгэлгүй байдалд зүрх сэтгэлээ хатууруулж, мөн үүнийг эсэргүүцэх тэдэнд энэ нь өөрсдөд нь зэмлэл болж хувирах болно—

16 Учир нь Их Эзэн Бурхан үүнийг ярьсан билээ; мөн сүмийн ахлагчид бид, дээд тэнгэрийн алдар суут Цог Жавхлант Түүний үгсийг сонссон, мөн гэрчлэх авай, түүнд алдар суу нь үүрд мөн үргэлж байх болтугай. Амен.

17 Эдгээр зүйлүүдээр эцэс төгсгөлгүй хийгээд мөнхийн, үүрд мөнхөөс үүрд мөнхөд үл өөрчлөгдөх, тэнгэр ба газар хийгээд тэдгээр дэх бүх зүйлүүдийг бий болгогч тэнгэрт оршигч “Бурхан буйг бид мэддэг билээ;

18 Мөн тэрбээр хүмүүнийг, эрэгтэй, эмэгтэйгээр нь өөрийнхөө “дүрээр мөн өөртэйгөө адилаар бүтээсэн билээ, тэднийг бүтээсэн нь тэрбээр болой;

8a су Урим ба Туммим.

9a су Сайн мэдээ. б ИС—Т 1:34.

10a Моро. 7:29–32; С ба Г 5:11.

б Мөн Мормоны Номны оршил хуудсан дахь Гурван гэрчийн гэрчлэл болон Найман гэрчийн гэрчлэлийг үз.

11a су Судрууд— Судруудын үнэ цэнэ.

б су Сүнсний удирдамж, Сүнслэгээр нөлөөлөгдөх.

в су Ариун.

12a Евр. 13:8;

1 Ниф. 10:18–19; Морм. 9:9–10; С ба Г 35:1; 38:1–4.

14a су Зөв шударга,

Зөв шударга ёс. б су Мөнх амьдрал; Өргөмжлөл.

15a су Итгэлгүй байдал.

17a Иош. 2:11.

су Бурхан, Бурхан тэргүүтэн.

б С ба Г 76:22–23.

18a Эхл. 1:26–27;

Мозая 7:27;

Ифер 3:14–17.

б су Бүтээх, Бүтээл.

19 Мөн тэд цорын ганц амьд хийгээд үнэн Бурхан түүнийг “хайрлаж, мөн ^бүйлчилж байх ёстой, мөн тэрээр тэдний ^вшүтэн биширвэл зохих тэрхүү цорын ганц нь байх ёстой хэмээх зарлигуудыг тэдэнд өгчээ.

20 Харин эдгээр ариун хуулиудыг зөрчсөнөөр хүн “хүсэл тачаангуй хийгээд ^бчөтгөрийн санаатай болж, мөн ^вунасан хүн болжээ.

21 Иймийн тул, түүний тухай өгөгдсөн тэдгээр судруудад энэ нь бичигдсэнчлэн Бүхнийг чадагч Бурхан өөрийн “Төрсөн Ганц Хүүгээ өгсөн ажгуу.

22 Тэрээр “уруу таталтуудад орсон хэдий ч тэдгээрт анхаарал тавьсан нь үгүй.

23 Тэрээр “цовдлогдож, нас нөгчин, мөн гурав дахь өдөртөө дахин ^ббосч ирсэн ажгуу;

24 Мөн “Эцэгийн баруун гар талд заларч, Эцэгийн тааллын дагуу бүхнийг чадагч хүчээр хаанчлахын тулд тэнгэрт ^бдээш одсон бөлгөө;

25 Ингэснээр түүний ариун нэрэнд “итгэн мөн баптисм

хүртэж, мөн итгэлд эцсээ хүртэл ^бтэвчсэн болгон нь аврагдах ёстой—

26 Зөвхөн цаг хугацааны “голчид махан биед түүнийг ирсэний дараа итгэгсэд төдийгүй, ^вариун бошиглогчдын үгст итгэдэг Ариун Сүнсний “бэлгээр бурханлигаар нөлөөлөгдөхөд ярьдаг байсан, бүх зүйл дээр түүний тухай үнэнээр ^вгэрчилдэг асан эхлэлээс байсан тэд бүгд, бүр түүнийг ирэхээс өмнө байсан болгон нь мөнх амьдралыг авах ёстой,

27 Мөн түүнчлэн, дараа нь ирэх ёстой тэд, Эцэгийн тухай мөн Хүүгийн тухай “гэрчилдэг Ариун Сүнсээр Бурханы ^ббэлгүүд хийгээд дуудлагуудад итгэх ёстой тэд буюу;

28 Тэрхүү Эцэг, Хүү, мөн Ариун Сүнс нь төгсгөлгүй хийгээд мөнхийн, эцэс төгсгөлгүй “нэг Бурхан болой. Амен.

29 Мөн бүх хүмүүн “наманчилж мөн Есүс Христийн нэрэнд итгэн, мөн түүний нэрэнд Эцэгийг бишрэн

19a Дэд хууль 11:1;

Мат. 22:37;

Моро. 10:32;

С ба Г 59:5–6.

б Дэд хууль 6:13–15.

в сү Үйлчлэл.

в сү Шүтэн бишрэх.

20a сү Тачаангуй,

Тачаангуй байдал.

б сү Чөтгөр.

в сү Эгэл хүн.

21a сү Цорын Ганц.

22a Мат. 4:1–11; 27:40.

23a сү Цовдлуулалт.

б сү Амилуулалт.

24a сү Тэнгэр дэх Эцэг;

Бурхан, Бурхан

тэргүүтэн—Эцэг

Бурхан.

б сү Дээшлэн одолт.

25a С ба Г 35:2; 38:4;

45:5, 8; 68:9;

76:51–53.

б сү Тэвчих.

26a С ба Г 39:1–3.

б Иаков 4:4; 7:11;

Мозая 13:33.

в Моисе 5:58.

сү Ариун Сүнс.

г сү Есүс Христ—

Есүс Христийн

төрөлт болон нас

баралтын тухай

бошиглол.

27a С ба Г 42:17.

б С ба Г 18:32.

28a Иохан 17:20–22;

3 Ниф. 11:27, 36.

сү Бурхан, Бурхан

тэргүүтэн.

29a сү Наманчлах,

Наманчлал.

шүтэж, мөн ^битгэлд түүний нэрэнд эцсээ хүртэл тэвчих ёстойг, эс бөгөөс тэд Бурханы хаант улсад ^ааврагдаж чадахгүйг бид мэднэ.

30 Мөн бидний Их Эзэн хийгээд Аврагч Есүс Христийн ^аач ивээлээр дамжсан ^бзөвтгөл нь шударга бөгөөд үнэн болохыг бид мэднэ;

31 Мөн түүнчлэн бидний Их Эзэн хийгээд Аврагч Есүс Христийн ач ивээлээр дамжсан ^аариусгал нь Бурханыг бүхий л ^бхүчин чадал, оюун, чадлаараа хайрлаж мөн үйлчлэх тэр бүгдэд шударга бөгөөд үнэнийг бид мэднэ.

32 Гэвч хүн ач ивээлээс ^аунаж мөн амьд Бурханаас холдох боломж буй;

33 Тиймийн тул тэд ^ауруу таталтанд унахгүйн тулд сүм анхааралтай байж мөн ямагт залбираг;

34 Тийм ээ, бүр ариусгагдсан тэд тэрчлэн анхааралтай байг.

35 Мөн эдгээр зүйлүүд үнэн бөгөөд мөн Иоханы илчлэлтүүдийн дагуух түүний номын бошиглол, ^аариун судрууд буюу Ариун Сүнсний бэлэг хийгээд хүчээр, Бурханы ^бдуу хоолой эсвээс тэнгэр

элчүүдийн тохинууллаар үүнээс хойш ирэх Бурханы илчлэлтүүд дээр ^анэмэх буюу түүнээс хасах аль аль нь байж үл болно гэдгийг бид мэднэ.

36 Мөн Их Эзэн Бурхан үүнийг ярилаа; мөн хүндэтгэл, сүр хүч, мөн алдар суу түүний ариун нэрэнд эдүгээ болон үргэлж өгөгддөг байх болтугай. Амен.

37 *Мөн дахин, баптисмын маягийн талаар сүмд өгөгдсөн зарлигийн замаар* — Бурханы өмнө өөрсдийгөө даруусгах тэд бүгд, мөн ^абаптисм хүртэхийг хүсэгчид мөн ^бхарууссан зүрх мөн гэмшсэн сэтгэлтэйгээр ирэгсэд, мөн үнэхээр бүх нүглүүдээс наманчилснаа сүмийн өмнө гэрчлэгсэд, мөн эцсээ хүртэл түүнд үйлчлэх ^ашийдвэр төгс, Есүс Христийн ^нэрийг өөрсөд дээрээ авахад бэлэн байгсад, мөн нүглүүдээсээ ^аангижрахын тулд Христийн Сүнсийг хүлээн авснаа өөрсдийн ^аажлуудаар үнэнхүү тунхагладаг тэд баптисмаар түүний сүмд хүлээн авагдах ёстой.

38 *Ахлагчид, санваартнууд, багш нар, диконууд, мөн Христийн сүмийн гишүүдийн үүрэг* — ^аТө-

29б су Итгэл.
 в су Аврал;
 Гэтэлгэлийн төлөвлөгөө.
 30а су Ач ивээл.
 б су Зөвтгөл, Зөвтгөх.
 31а су Ариусгал.
 б Дэд хууль 6:5; Моро. 10:32.
 32а су Урвалт;

Эсэргүүцэл.
 33а су Уруу татах, Уруу таталт.
 35а су Судрууд.
 б С ба Г 18:33–36.
 в Илч. 22:18–19.
 37а су Баптисм, Баптисм хүртээх.
 б су Харууссан зүрх.
 в су Тэвчих.
 г Мозая 5:7–9; 18:8–10.

су Есүс Христ—
 Өөрсөд дээрээ Есүс Христийн нэрийг авах.
 д су Нүглүүдийн ангижрал.
 е Иаков 2:18.
 су Ажлууд.
 38а су Төлөөлөгч.

лөөлөгч бол ахлагч юм, мөн ^ббаптисм хүртээх нь түүний дуудлага болой;

39 Мөн бусад ахлагчид, санваартнууд, багш нар, диконуудыг “томилох нь болой;

40 Мөн Христийн бие хийгээд цусны бэлэгдэл — талх дарсыг “адислах нь болой —

41 Мөн сүмд баптисм хүртэгчдийг судруудын дагуу, галын баптисм болон “Ариун Сүнсний тулд ^бгар тавилтаар “батлах нь болой;

42 Мөн заах, тайлбарлах, ухуулах, баптисм хүртээх, мөн сүмийг харж хандах нь болой;

43 Мөн гар тавилтаар мөн Ариун Сүнс өгөлтөөр сүмийг батлах нь болой;

44 Мөн бүх цуглааныг удирдах нь болой.

45 Ахлагчид Бурханы зарлигууд хийгээд илчлэлтүүдийн дагуу тэд Ариун Сүнсээр удирдагдан цуглаануудыг “хөтлөн явуулах ёстой.

46 “Санваартны үүрэг нь номлох, ^бзаах, тайлбарлах, ухуулах, мөн баптисм хүртээх, мөн ариун ёслолыг гүйцэтгэх нь болой,

47 Мөн гишүүн бүрийн гэрээр айлчлан, мөн “чанга дуугаар болон чимээгүй ^бзалбирахыг, мөн “гэр бүлийн бүх

үүргээ гүйцэтгэхийг тэдэнд ухуулах нь болой.

48 Мөн тэрээр бас бусад санваартнууд, багш нар хийгээд диконуудыг “томилж болно.

49 Мөн тэрээр ахлагч байхгүй үед цуглаануудыг удирдах ёстой;

50 Харин ахлагч байгаа үед тэрээр зөвхөн номлож, зааж, тайлбарлаж, ухуулж мөн баптисм хүртээх ёстой,

51 Мөн гишүүн бүрийн гэрээр айлчлан, мөн чанга дуугаар болон чимээгүй залбирахыг, мөн гэр бүлийн бүх үүргээ гүйцэтгэхийг тэдэнд ухуулах нь болой.

52 Эдгээр бүх үүргүүдэд санваартан нь нөхцөл байдал шаардах аваас ахлагчид “туслах ёстой.

53 “Багшийн үүрэг нь сүмийг ямагт ^бхарж хандах, мөн тэдэнтэй хамт байж мөн бэхжүүлэх нь болой;

54 Мөн сүмд алдас байхгүй, мөн бие биендээ “хахир хатуу хандахгүй, мөн худал хэлэхгүй, хов жив хөөцөлдөхгүй, мөн ^бшүүмжлэхгүй байхад анхаарах нь болой;

55 Мөн сүм хамтдаа олонтаа цуглахыг анхаарч, мөн тэрчлэн бүх гишүүд үүргээ биелүүлж байгааг анхаарах нь болой.

38б 3 Ниф. 11:21–22.

39а Моро. 3:1–4;

С ба Г 107:58.

40а су Ариун ёслол.

41а су Ариун Сүнсний бэлэг.

б су Гар тавих.

в С ба Г 33:11, 14–15;

55:3.

45а Моро. 6:9;

С ба Г 46:2.

46а С ба Г 84:111; 107:61.

су Санваартан,

Аароны санваар.

б су Заах, Багш.

47а С ба Г 19:28.

б 1 Тим. 2:8.

в су Гэр бүл.

48а су Томилох,

Томилолт.

52а С ба Г 107:14.

53а су Багш, Аароны

санваар.

б су Харах, Харуул.

54а 1 Тес. 5:11–13.

б су Хилэнцэтийг

ярих.

56 Мөн ахлагч буюу санваартан байхгүй үед тэрээр цуглаануудыг удирдах ёстой —

57 Мөн сүм дэх өөрийн бүх үүргүүдэд, хэрэв нөхцөл байдал шаардах аваас “диконуудаар байнга туслуулж байх ёстой.

58 Гэвч багш нар ч мөн диконууд ч баптисм хүртээх, ариун ёслолыг гүйцэтгэх, эсвээс гар тавих эрх мэдэлгүй болой;

59 Гэсэн хэдий ч, тэд сануулж, тайлбарлаж, ухуулж, мөн зааж, мөн Христэд ирэхэд бүхнийг урьдаг байх ёстой.

60 “Ахлагч, санваартан, багш буюу дикон бүр өөрт нь түүнд өгөгдсөн Бурханы бэлгүүд хийгээд ^бдуудлагуудын дагуу томилогддог байх ёстой; мөн тэрээр өөрийг нь томилох нэгэнд байдаг тэрхүү Ариун Сүнсний хүчээр томилогддог байх ёстой.

61 Христийн энэ сүмийг бүрдүүлэгч хэд хэдэн ахлагчид гурван сард нэг удаа буюу эсвээс энд дурдсан чуулгануудын чиглүүлсэн буюу товлосноор цагаас цагт чуулганд цуглах ёстой;

62 Мөн дурдсан чуулганууд нь тухайн үед хийгдэх нь чухал байгаа сүмийн аливаа ажлыг хийх ёстой.

63 Ахлагч нар өөрсдийн

үнэмлэхийг бусад ахлагчдаас, өөрсдийн харьяалагддаг сүмийн “саналаар буюу чуулгануудаас хүлээж авах ёстой.

64 Санваартнаар томилогддог санваартан, багш буюу дикон бүр, ахлагчид танилцуулагдах үед дуудлагынхаа үүргүүдийг гүйцэтгэх эрх мэдлийг түүнд өгөх үнэмлэхтэй болгох “гэрчилгээг тухайн үедээ түүнээс авч болох буюу эсвээс тэрээр үүнийг чуулгаас хүлээн авч болно.

65 Албан ёсоор зохион байгуулагдсан уг сүмийн салбар байгаа үед сүмийн “саналгүйгээр нэг ч хүн энэ сүмийн ямар ч албан тушаалд ^бтомилогдох ёсгүй;

66 Гэвч тэргүүлэгч ахлагчид, аялагч бишопууд, дээд зөвлөхүүд, дээд санваартнууд, мөн ахлагчид санал хураалт явагдах сүмийн салбар байхгүй газарт томилох онцгой боломжтой байж болно.

67 Дээд санваартны ерөнхийлөгч бүр (эсвээс тэргүүлэгч ахлагч) “бишоп, дээд зөвлөх мөн ^бдээд санваартан нь “дээд зөвлөл буюу ерөнхий чуулганы чиглүүлгээр томилогдох ёстой.

68 *Баптисмаар тэд хүлээн авагдсаны дараах гишүүдийн “үүрэг.* —^бАриун ёслолоос тэд хүртэх хийгээд ахлагчдаас ^бгар тавилтаар батлагдахын

57a су Дикон.
60a су Ахлагч.
б су Дуудах,
Бурханаас
дуудагдах,
Дуудлага.
63a су Нийтийн

дэмжлэг.
64a С ба Г 20:84; 52:41.
65a С ба Г 26:2.
су Нийтийн
дэмжлэг.
б су Томилох,
Томилолт.

67a су Бишоп.
б су Дээд
санваартан.
в су Дээд зөвлөл.
68a су Үүрэг.
б су Ариун ёслол.
в су Гар тавих.

өмнө, бүх зүйлүүд эмх цэгцэд хийгдсэн байж болохын тулд ахлагчид буюу санваартнууд Христийн сүмийн талаарх бүх зүйлийг тэдний 'ойлголт-ын тулд тайлбарлах хангалттай цагтай байх ёстой.

69 Мөн гишүүд нь ариун судруудад нийцэх “ажлууд хийгээд итгэл—Их Эзэний өмнө ^бцэвэр ариун байдалд алхах нь байж болохын тулд сүмийн өмнө, мөн тэрчлэн ахлагчдын өмнө үүнд зохистой гэдгээ тэд бурханлиг алхаа хийгээд яриагаараа харуулах ёстой.

70 Христийн сүмийн хүүхэдтэй гишүүн бүр тэднийг сүмийн өмнө ахлагчдад авчрах ёстой, тэд Есүс Христийн нэрээр тэдэн дээр гар тавин, мөн түүний нэрээр тэднийг “адислах ёстой.

71 Тэрээр Бурханы өмнө “хариуцлагын насанд хүрсэн бөгөөд ^бнаманчлах чадвартай байхаас бусдаар хэн ч Христийн сүмд хүлээн авагдаж чадахгүй.

72 Наманчилдаг тэд бүгдэд “баптисм нь дараах маягаар гүйцэтгэгддэг байх ёстой—

73 Бурханаас дуудагдаж, мөн баптисм хүртээх эрх мэдлийг Есүс Христээс авсан хүн, өө-

рийгөө баптисмд авчирсан тэр хүний хамт ус уруу орж, түүнийг нэрээр нь дуудан хэлэх нь: Есүс Христийн итгэмжилснээр би танд Эцэг, мөн Хүү, мөн Ариун Сүнсний нэрээр баптисм хүртээж байна. Амен.

74 Тэгээд тэрээр түүнийг усанд “умбуулж, мөн уснаас дахин гаргана.

75 Сүм нь Их Эзэн Есүсийг “дурсан санаж, талх болон дарсыг ^бхүртэхийн тулд олон-таа хамтдаа цуглах нь зүйтэй болой;

76 Мөн ахлагч буюу санваартан үүнийг гүйцэтгэх ёстой; мөн тэрээр энэ “маягаар үүнийг гүйцэтгэх ёстой—тэрээр сүмийнхэнтэй хамт сөгдөн сууж чин сэтгэлийн залбиралд хэлэх нь:

77 Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, үүнээс хүртэх тэд бүгдийн бодгалийн тулд; тэд түүний “Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж болохын тулд таны Хүүгийн биеийг төлөөлөн дурсаж, тэд үүнийг идэж, Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, тэд өөрсдөдөө таны Хүүгийн нэрийг ^бавч, мөн үргэлж түүнийг санаж, мөн өөрсдөд нь өгсөн түүний зарлигуудыг

68г су Мэдлэг.

69а Иаков 2:14–17.

б су Ариун байдал.

70а су Адислах,

Адислагдсан,

Адислал—Хүүхдийн

адислал.

71а С ба Г 18:42; 29:47;

68:25–27.

су Хариуцах,

Хариуцлага,

Хариуцлагатай;

Баптисм, Баптисм

хүртээх—Баптисмд

тэнцэх.

б су Наманчлах,

Наманчлал.

72а 3 Ниф. 11:22–28.

74а су Баптисм,

Баптисм хүртээх—

Умбуулах баптисм.

75а су Ариун ёслол.

б Үйлс 20:7.

76а Моро. 4:1–3.

77а Иохан 14:16.

б Мозая 5:8–12.

⁶дагахад бэлэн гэдгээ танд гэрчилж болохын тулд, энэ ⁶талхыг адисалж мөн ариулахыг таны Хүү, Есүс Христийн нэрээр бид танаас гуйж байна. Амен.

78 Дарсыг адислах “маяг нь гэвэл— тэрээр тэрчлэн ⁶аягыг авч, мөн хэлэх нь:

79 Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, үүнээс уух тэд бүгдийн бодгалийн тулд, тэд түүний Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгаж болохын тулд, өөрсдийнх нь төлөө асгаруулсан таны Хүүгийн цусыг төлөөлөн дурсаж, тэд үүнийг үйлдэж болохын тулд; Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, тэд үргэлж түүнийг санана гэдгээ танд гэрчилж болохын тулд, энэ “дарсыг адисалж, мөн ариулахыг таны Хүү Есүс Христийн нэрээр бид танаас гуйж байна. Амен.

80 Гэм бурууг үйлдсэн буюу дутагдал гаргасан Христийн сүмийн аль ч гишүүн судруудын чиглүүлгийн дагуу зохицуулагдах ёстой.

81 Христийн сүмийг бүрдүүлэгч хэд хэдэн сүмийн үүрэг нь өөрсдийнхөө нэг буюу түүнээс дээш багш нарыг сүмийн ахлагч нараар зохион байгуулагддаг хэд хэ-

дэн чуулганд оролцуулахаар илгээх явдал байх болно,

82 Сүүлчийн чуулганаас хойш сүмтэй өөрсдийгөө нэгтгэсэн хэд хэдэн гишүүний “нэрсийн жагсаалтын хамт буюу; эсвээс хэн нэг санваартны гараар илгээх ажгуу; тийнхүү нийт сүмийн байнгын нэрсийн жагсаалт цагаас цагт бусад ахлагчид томилох ахлагч нарын нэгнээр нь бүртгэлд хадгалагдах ёстой;

83 Мөн тэрчлэн, хэрэв хэн нэгэн нь сүмээс “хөөгдсөн бол тэдний нэрс сүмийн нэрсийн ерөнхий бүртгэлээс хасагдаж болно.

84 Өөрсдийнхөө харьяалагдаг сүмээс шилжиж буй бүх гишүүд, хэрэв өөрсдийг нь үл мэдэх сүмд очиж байгаа бол, тэд өөрсдийг нь албан ёсны гишүүн болохыг нь, мөн сайн байдалд байгааг нь нотолсон захидлыг авч очиж болно, хэрэв уг захидлыг хүлээн авч байгаа гишүүн уг ахлагч буюу санваартныг хувиараа таньдаг бол уг гэрчилгээ нь аль ч ахлагч буюу санваартнаар гарын үсэг зурагдсан байж болно, эсвээс энэ нь тухайн сүмийн багш нар буюу диконуудаар гарын үсэг зурагдсан байж болно.

77в су Дуулгавартай байх, Дуулгавартай, Дуулгавартай дагах.
г Мозая 18:8–10;

С ба Г 20:37.
д Лук 22:19.
78а Моро. 5:1–2.
б Лук 22:20.
79а С ба Г 27:2–4.

82а Моро. 6:4.
83а Ег. 32:33;
Алма 5:57;
Моро. 6:7.
су Сүмээс хөөх.

ХЭСЭГ 21

1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд Нью-Йоркийн Фейеттед Бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:74–79). Энэхүү илчлэлт нь дурдсан өдөр Сүмийг зохион байгуулахад, Ахмад Петр Витмерийн гэрт өгөгдсөн ажээ. Өмнөхөн нь баптисм хүртсэн зургаан хүн оролцжээ. Бурханы зарлигийн дагуу эдгээр хүмүүс зохион байгуулах өөрсдийн хүсэл хийгээд төгс шийдвэрийг нэгдмэл саналаар илэрхийлсэн байлаа (хэсэг 20-ийг үз). Тэрчлэн тэд Бага Иосеф Смит, мөн Оливер Каудери нарыг Сүмийн тэргүүлэх ажилтнуудаар хүлээн зөвшөөрч мөн дэмжихээр санал өгсөн бөлгөө. Дараа нь Иосеф гар тавилтаар Оливерыг Сүмийн ахлагчаар томилов, мөн Оливер нэгэн адилаар Иосефыг томилов. Ариун ёслолыг гүйцэтгэсний дараа, хүн бүрт Ариун Сүнс хүртээхийн тулд мөн Сүмийн гишүүнээр батлахын тулд Иосеф мөн Оливер оролцогчид дээр тус бүрд нь гар тавив.

1–3, Иосеф Смит үзмэрч, орчуулагч, бошиглогч, төлөөлөгч, мөн ахлагч байхаар дуудагдав; 4–8, Түүний үг Сионы ашиг сонирхлыг удирдах болно; 9–12, Тайтгаруулагчаар тэрбээр ярихад Гэгээнтнүүд түүний үгсэд итгэх болно.

БОЛГООГТУН, та нарын дунд “цэдэг хөтлөгдөх болно; мөн Бурхан Эцэгийн таалал хийгээд мөн чиний Их Эзэн Есүс Христийн ач ивээлээр дамжин үүнд чи ^бүзмэрч, орчуулагч, бошиглогч, Есүс Христийн ^өтөлөөлөгч, мөн сүмийн ахлагч хэмээн дуудагдах болно,

2 Үүний суурийг тавихад болон хамгийн ариун итгэлд үүнийг өсгөн бэхжүүлэхийн

тулд Ариун Сүнсээр “нөлөөлөгдсөн болой.

3 Уг “сүм нь та нарын Их Эзэний мянга найман зуун гучин оны, дөрөв дэх сард, мөн Апрель хэмээн нэрлэгдэх уг сарын зургаа дахь өдөр ^бзохион байгуулагдаж мөн үндэслэгдсэн бөлгөө.

4 Иймийн тул, сүмийн тухайд, тэрээр тэдгээрийг хүлээн авсан үед, та нар миний өмнө бүхий л “цэвэр ариун байдалд алхан, та нарт түүний өгөх түүний бүх ^бүгсэд хийгээд зарлигуудад анхаарал тавигтун;

5 Учир нь түүний “үгийг та нар миний амнаас гарсан мэтээр бүхий л тэвчээр хийгээд итгэлд хүлээн авах ёстой.

6 Учир нь эдгээр зүйлүү-

21 1а С ба Г 47:1;
69:3–8; 85:1.
б су Үзмэрч.
в су Төлөөлөгч.
2а су Сүнсний
удирдамж,
Сүнслэгээр

нөлөөлөгдөх.
3а су Есүс Христийн
Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн
Сүм.
б С ба Г 20:1.
4а су Ариун байдал.

б су Судрууд.
5а С ба Г 1:38.
су Сүмийн
удирдагчдыг
дэмжих;
Бошиглогч.

дийг хийснээр тамын “үүд та нарыг дийлэх нь үгүй; тийм ээ, мөн Их Эзэн Бурхан ^бхаранхуйн хүчийг та нарын өмнөөс сарниулж, мөн та нарын сайн сайхан хийгээд түүний нэрийн ^аалдар суугийн төлөө тэнгэрийг ^ссэгсрэхэд хүргэх болно.

7 Учир нь Их Эзэн Бурхан ийн хэлэх ажгуу: Сайн сайхны төлөө хүчирхэг хүч чадалд “Сионы ашиг сонирхлыг урагш ахиулахын тулд би түүнд бурханлигаар нөлөөлсөн билээ, мөн түүний хичээл зүтгэлийг мэднэ би, мөн түүний залбирлуудыг сонссон бөлгөө би.

8 Тийм ээ, Сионы төлөө түүний уйлахыг харсан билээ би, мөн тэрээр түүний төлөө гашуудахыг нь эцэс болгоно би; учир нь түүний баяр баяслын өдрүүд нь нүглүүдийнх нь “ангижралаар, мөн түүний ажлууд дээр миний адислалуудын илэрхийлэл ирэх ёстой.

9 Учир нь, болгоогтун, ми-

ний “талбайд хөдөлмөрлөх тэднийг бүгдийг нь би хүчирхэг адислалаар ^бадислах болно, мөн ^ддэлхийн нүглүүдийн төлөө тийм ээ, ^{*}харууссан зүрхтэнгүүдийн нүглүүдийн ангижралын төлөө Есүс ^ннүгэлт хүмүүсээр ^оцовдлогдсоныг ^иилэрхийлдэг ^тТайтгаруулагчаар, надаар дамжуулан түүнд өгөгдсөн түүний үгсэд тэд итгэх болно.

10 Иймийн тул миний төлөөлөгч Оливер Каудери, чамаар тэр “томилогдох ёстой нь миний таалал болой;

11 Чи миний нэрийг хэрэглэх Христийн энэ сүмд ахлагч байж болохын тулд чи түүний гар дор ахлагч байх нь чиний томилолт бөлгөө, тэрбээр чамд “анхдагч байх авай—

12 Мөн сүмд энэ сүмийн анхны номлогч, мөн дэлхийн өмнө, тийм ээ, Харийнханы өмнө, тийм ээ, харагтун, харагтун тэрчлэн “Иудейчүүдэд бөлгөө! ийн Их Эзэн Бурхан хэлнэм. Амен.

ХЭСЭГ 22

1830 оны дөрөвдүгээр сард Нью-Йоркийн Манчестерт Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1: 79–80). Энэхүү илчлэлт өмнө нь баптисм хүртсэний

6а Мат. 16:18;
 С ба Г 10:69.
 б Кол. 1:12–13.
 в су Алдар суу.
 г С ба Г 35:24.
 7а су Сион.
 8а С ба Г 20:5–6.
 9а су Их Эзэний талбай.

б 1 Ниф. 13:37;
 Иаков 5:70–76.
 в 1 Иохан 2:2.
 су Дэлхий—
 Зарлигуудыг дуулгавартай дагадаггүй хүмүүс.
 г су Нүгэл.
 д су Цовдлуулалт.

е су Гэрчлэх.
 ё су Тайтгаруулагч.
 ж су Харууссан зүрх.
 10а су Томилох, Томилолт.
 11а С ба Г 20:2.
 12а 1 Ниф. 13:42;
 С ба Г 19:27; 90:8–9.

улмаас зарим хүмүүс баптисмыг дахин хийлгэхгүйгээр Сүмтэй нэгдэх хүсэлтэй байсны учир Сүмд өгөгдсөн ажээ.

1, Баптисм бол шинэ бөгөөд үүрдийн гэрээ мөн; 2–4, Эрх мэдэл бүхий баптисм шаардлагатай.

БОЛГООГТУН, “хуучин бүх Гэрээнүүд энэ зүйлээр дуусгавар болсон байхаар би болгосныг би та нарт хэлж байна; мөн энэ бол бүр эхлэлээс байсан тэрхүү шинэ бөгөөд үүрдийн гэрээ юм.

2 Иймийн тул, хэдийгээр хүн зуун удаа баптисм хүртсэн байлаа ч гэсэн энэ нь түүний хувьд ямар ч хэрэггүй

юм, учир нь та нар Мосегийн “хуулиар, бас өөрсдийн үхмэл ажлуудаар ч шулуун хаалганд орж чадах нь үгүй.

3 Учир нь энэ нь та нарын үхмэл ажлуудын улмаас би энэ сүүлчийн гэрээ болон энэ сүм бүр эрт дээр үеийнхтэй адилаар надад өсгөн бэхжүүлэгдэхэд хүргэсэн бөлгөө.

4 Иймийн тул, миний зарлигласанчлан, “тэр хаалганд орогтун та нар, мөн Бурхандаа зөвлөгөө өгөхийг бүү эрэлхийл. Амен.

ХЭСЭГ 23

1830 оны дөрөвдүгээр сард Нью-Йоркийн Манчестерт Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Оливер Каудери; Хайрум Смит; Самуел Х.Смит; Ахмад Иосеф Смит; мөн Ахмад Иосеф Найт нарт өгөгдсөн илчлэлт оршвой. (History of the Church, 1:80). Нэрлэгдсэн таван хүн өөр өөрсдийн үүргийг мэдье хэмээн чин сэтгэлээсээ хүссэн учир Их Эзэнээс Бошиглогч асууж мөн энэхүү илчлэлтийг хүлээн авчээ.

1–7, Эдгээр анхны шавь нар номлох, ухуулах, мөн Сүмийг бэхжүүлэхээр дуудагдав.

БОЛГООГТУН, Оливер чамд би хэдэн үг хэлье. Болгоогтун, адислагдсан болой чи, мөн зэмлэл дор орших нь үгүй бөлгөө. Гэвч чи “уруу таталтанд орохгүйн

тулд бардамналаас болгоомжил.

2 Өөрийнхөө дуудлагыг сүмд, мөн тэрчлэн дэлхийн өмнө мэдүүлэгтүн, мөн энэ үеэс эхлэн мөн үүрд мөнхөд зүрх сэтгэл чинь үнэнийг номлохоор нээгдэх болно. Амен.

3 Болгоогтун, Хайрум чамд

22 1а Евр. 8:13;
3 Ниф. 12:46–47.
б С ба Г 66:2.
су Гэрээ; Шинэ бөгөөд үүрдийн Гэрээ.
2а Гал. 2:16.

су Мосегийн хууль.
б Моро. 8:23–26.
4а Мат. 7:13–14;
Лук 13:24;
2 Ниф. 9:41;
31:9, 17–18;
3 Ниф. 14:13–14.

су Баптисм,
Баптисм хүртээх.
б Иаков 4:10.
23 1а су Уруу татах,
Уруу таталт.
б су Бардамнал.

би хэдэн үг хэлье; учир нь чи тэрчлэн зэмлэл дор орших нь үгүй, мөн зүрх сэтгэл чинь нээгдсэн, мөн хэл чинь чөлөөтэй болсон бөлгөө; мөн дуудлага чинь ухуулга хийгээд сүмийг байнга “бэхжүүлэх нь болой. Иймийн тул чиний үүрэг сүмд үүрд мөнхийн юм, мөн энэ нь гэр бүлийнхний чинь улмаас бөлгөө. Амен.

4 Болгоогтун, “Самуел чамд би хэдэн үг хэлье; учир нь чи тэрчлэн зэмлэл дор орших нь үгүй, мөн дуудлага чинь ухуулга хийгээд сүмийг бэхжүүлэх нь болой; мөн чи дэлхийн өмнө номлохоор хараахан дуудагдаагүй бөлгөө. Амен.

5 Болгоогтун, Иосеф чамд би хэдэн үг хэлье; учир нь чи

тэрчлэн зэмлэл дор орших нь үгүй, мөн дуудлага чинь ухуулга хийгээд сүмийг бэхжүүлэх нь болой; мөн энэ үеэс эхлэн мөн үүрд мөнхөд энэ нь чиний үүрэг бөлгөө. Амен.

6 Болгоогтун, чи “загалмайгаа үүрэх ёстой, ингэхийн тулд чи дэлхийн өмнө мөн гэр бүлдээ, мөн найз нөхдийнхөө дунд, мөн бүхий л газруудад ⁶чангаар түүнчлэн чимээгүй ⁶залбирах ёстой гэдгийг Иосеф Найт чамд би эдгээр үгсээр илэрхийлж байна.

7 Мөн, болгоогтун, чи хөдөлмөрлөгчийн шагналыг хүлээн авч болохын тулд үнэн сүмтэй “нэгдэж, мөн ухуулгад үг хэлээ үргэлж зориулах нь чиний үүрэг болой. Амен.

ХЭСЭГ 24

1830 оны долдугаар сард Пеннсильванийн Хармонид Бошиглогч Иосеф Смит Оливер Каудери хоёрт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:101–103). Сүм зохион байгуулагдсанаас хойш дөрвөн сар ч өнгөрөөгүй байхад мөрдлөг хавчлага нэн хүчтэй болж, удирдагчид хэсэг хугацаанд нуугдмал байж аюулгүй байдлыг эрэлхийлэхээс аргагүйд хүрэв. Энэ үед тэдэнд хүч өгч, зоригжуулан мөн зааварлахын тулд дараах гурван илчлэлт өгөгдсөн ажээ.

1–9, Иосеф Смит орчуулах, номлох, мөн судруудыг тайлбарлахаар дуудагдав; 10–12, Оливер Каудери сайн мэдээг номлохоор дуудагдав; 13–19, Гайхамигууд, зүхлүүд, хөлийн тоос гүвэх хийгээд хэтэвч буюу аяны цүнхгүй-

гээр явахтай холбогдсон хууль илчлэгдэв.

БОЛГООГТУН, чи Мормоны Номыг бичихээр, мөн миний тохинуулалд дуудагдаж мөн сонгогдсон авай;

3а С ба Г 81:4–5; 108:7.
4а ИС—Т 1:4.
6а Мат. 10:38;

3 Ниф. 12:30.
б С ба Г 20:47, 51.
в су Залбирал.

7а су Баптисм,
Баптисм хүртээх—
Чухал шаардлага.

мөн бибээр чамайг зовлон зүдгүүрүүдээс чинь гарган авлаа, мөн чамд зөвлөгөө өглөө, ингэснээр чи бүх дайснуудаасаа чөлөөлөгдсөн бөлгөө, мөн чи Сатаны хүч хийгээд харанхуйгаас чөлөөлөгдсөн билээ!

2 Гэсэн хэдий ч, чи “зөрчлүүддээ зөвтгөгдөхгүй; гэсэн хэдий ч, замаараа явж, мөн дахин нүгэл бүү үйлд.

3 Албан тушаалаа “эрхэмлэн биелүүлэгтүн; мөн чи талбайнуудаа тариалж тэдгээрийг хамгаалсны дараа “Колесвилл, Фейетте, мөн Манчестер дахь сүм уруу яаран явагтун, мөн тэд чамайг “дэмжих болно; мөн бибээр тэднийг сүнслэг хийгээд эд материалын талаар аль алианаар нь адислах болно;

4 Гэвч хэрэв тэд чамайг хүлээн авахгүй бол, адислалын оронд зүхлийг бибээр тэдэн дээр илгээх болно.

5 Мөн миний нэрээр Бурханд хандан залбирахаа, мөн “Тайтгаруулагчаар чамд өгөгдөх тэр зүйлүүдийг бичихээ, мөн бүх судруудыг сүмд тайлбарлахаа чи үргэлжлүүлэх ёстой.

6 Мөн “ярьж мөн бичих тэр зүйл чинь яг тэр мөчид чамд өгөгдөх болно, мөн тэд үүнийг сонсох ёстой, эсвээс бибээр тэдэнд адислалын

оронд зүхлийг илгээх болно.

7 Учир нь чи бүхий л “үйлчлэлээ Сионд зориулах ёстой; мөн үүнд чи хүч чадалтай байх болно.

8 “Зовлон зүдгүүрүүдэд “гэвчээртэй байгтун, учир нь чамд эдгээр нь олон байх болно; гэвч тэдгээрийг “гэсвэрлэ, учир нь, харагтун, би чамтай, бүр чиний өдрүүдийн “төгсгөл хүртэл хамт байх болно.

9 Мөн цаг зуурын хөдөлмөрүүдэд чи хүчирхэгжих нь үгүй, учир нь энэ бол чиний дуудлага биш. “Дуудлагадаа өөрийгөө зориул мөн албан тушаалаа эрхэмлэн биелүүлэх, мөн бүх судруудыг тайлбарлах, мөн гар тавилтыг үргэлжлүүлэх, мөн сүмийнхнийг баталсаар байхад шаардлагатай зүйлс чамд байх болно.

10 Мөн Оливер ах чинь дэлхийн өмнө мөн тэрчлэн сүмд миний нэрийг гэрчлэхээ үргэлжлүүлэх ёстой. Мөн тэрээр миний ашиг сонирхолд хангалттайг хэлж чадна хэмээн тэрээр бодох ёсгүй; мөн харагтун, бибээр төгсгөл хүртэл түүнтэй хамт байх болно.

11 Сул доройд ч байна уу, чадалд ч байна уу, дарлалд ч байна уу, чөлөөтэй ч байна уу, тэрээр өөрөөсөө

24 2a С ба Г 1:31–32.

3a Иаков 1:19; 2:2.

б С ба Г 26:1; 37:2.

в С ба Г 70:12.

5a су Тайтгаруулагч.

6a Ег. 4:12;

Мат. 10:19–20;

Лук 12:11–12;

Хил. 5:18–19;

С ба Г 84:85; 100:5–8;

Моисе 6:32.

7a су Үйлчлэл.

8a су Дайсан.

б су Тэвчээр.

в су Тэвчих.

г Мат. 28:20.

9a су Даамал, Ажил

үүрэг.

бус харин надад алдар сууг олох болно;

12 Мөн бүхий л цагт, мөн бүх газарт, тэрбээр амаа нээж мөн өдөр шөнийн алинд ч “бүрээн дуугаар мэт миний сайн мэдээг ^бтунхаглах ёстой. Мөн хүмүүний дунд мэдэгдээгүй тийм чадлыг бибээр түүнд өгөх болно.

13 Та нарт миний “зарлиглахаас бусдаар, ^бчөтгөрүүдийг “зайлуулах, өвчтэйг “эдгээх, мөн ^бхорт могойнуудын эсрэг мөн үхлийн аюулт хорнуудын эсрэг биш аваас ^ггайхамшгуудыг бүү шаард;

14 Судрууд биелэгдэж болохын тулд, энэ нь та нараас үүнийг хүсэгч тэднээр шаардахаас бусдаар, “эдгээр зүйлүүдийг та нар хийх ёсгүй бөлгөө; учир нь бичигдсэн тэрний дагуу та нар үйлдэх ёстой.

15 Мөн та нар ямар ч газарт “орлоо гэсэн, мөн тэд та нарыг миний нэрэнд эс хүлээн авбал, тэдний эсрэг гэрчлэл болгон хөлийнхөө ^бтоосыг гүвснээр мөн замын хажууд

хөлөө цэвэрлэснээр та нар адислалын оронд зүхлийг үлдээх ёстой.

16 Мөнхүү улиран тохиох дор та нарын дээр хүчирхийллээр гараа далайх хэн боловч, миний нэрэнд арчигдахыг та нар зарлиглах ёстой; мөн, болгоогтун, өөрийнхөө тогтоосон цагт, та нарын үгсийн дагуу би тэднийг цохих болно.

17 Мөн та нартай хуулиар заргалдах хэн боловч тэрхүү хуулиар зүхэгдэх болно.

18 Мөн та нар “хэтэвч буюу аяны цүнх, мөн таягийг ч, хос цувыг ч, авч явахгүй байх ёстой, учир нь та нарт хэрэгтэй хоол хүнс хийгээд хувцас хунар мөн гутал хийгээд мөнгө бас аяны цүнхийг яг хэрэгтэй цагт чинь сүм та нарт өгөх болно.

19 Учир нь миний талбайг хүчирхэг тайралтаар, тийм ээ, бүр эцсийн удаа “тайрахаар та нар дуудагдсан билээ; тийм ээ, мөн тэрчлэн та нарын ^бтомилсон тэд бүгд болой, мөн тэд бүр энэ загварын дагуу үйлдэх ёстой. Амен.

ХЭСЭГ 25

1830 оны долдугаар сард Пеннсильванийн Хармонид Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:103–104). (Хэсэг 24-ийн толгой гарчгийг үз.) Энэхүү

12a С ба Г 34:6.

б су Номлох.

13a 1 Ниф. 17:50.

б су Сүнс—Муу ёрын сүнснүүд.

в Марк 16:17.

г су Эдгээх, Эдгэрэх.

д Үйлс 28:3–9;

С ба Г 84:71–72;

124:98–99.

е су Гайхамшиг;

Тэмдэг.

14a су Өвчтөнийг эдгээх.

15a Мат. 10:11–15.

б Марк 6:11;

Лук 10:11;

С ба Г 60:15;

75:19–22; 99:4–5.

18a Мат. 10:9–10;

Лук 10:4;

С ба Г 84:78–79.

19a Иаков 5:61–74;

С ба Г 39:17; 71:4.

б су Томилох,

Томилолт.

илчлэлт Бошиглогчийн эхнэр Эмма Смитэд хандсан Их Эзэний тааллыг илэрхийлдэг.

1-6, Сонгогдсон хатагтай Эмма Смит, нөхөртөө тусалж мөн тайтгаруулахаар дуудагдав; 7-11, Тэрчлэн тэрээр бичих, судруудыг тайлбарлах, мөн сүмийн дууллуудыг сонгохоор дуудагдсан бөлгөө; 12-14, Зөв шударгыг үйлдэгчдийн дуу бол Их Эзэнд хандсан залбирал болой; 15-16, Энэхүү илчлэлт дэх дуулгавартай байдлын зарчмууд нь бүхний хувьд хэрэглэгдэхүйц ажгуу.

АНХААРАГТУН, намайг Аөөрт чинь хандан ярих үед Их Эзэн Бурханыхаа дуу хоолойг, Эмма Смит, охин минь; учир нь үнэнээр би чамд хэлнэ, миний сайн мэдээг “хүлээн авах тэд бүгд миний ⁶хаант улсын хөвгүүд мөн охид билээ.

2 Би тааллынхаа талаар чамд нэг илчлэлт өгч байна; мөн чи итгэлтэй байж мөн миний өмнө “ариун журмын замаар ⁶алхлах аваас, би чиний амь насыг хамгаалах болно, мөн чи Сионд ⁶өв хүлээн авах болно.

3 Болгоогтун, “нүглүүд чинь чамд өршөөгдсөн болой, мөн чи бол миний ⁶дуудсан, сонгогдсон хатагтай болой.

4 Үзээгүй юмсынхаа улмаас болж чи бүү бувтна, учир нь тэдгээр нь чамд хийгээд дэлхийд өгөгдөөгүй нь ирэх цагт надад орших мэргэн ухаан бөлгөө.

5 Мөн чиний дуудлагын албан тушаал нь өөрийн нөхөр, миний үйлчлэгч Бага Иосеф Смитэд, түүний зовлон зүдгүүрүүдэд тайвшруулагч үгсээр номхон дөлгөөн байдлын сүнсэнд “тайвшрал өгөх явдал болно.

6 Мөн чи түүнийг явах үед нь түүнтэй хамт явж, мөн би өөрийн үйлчлэгч, Оливер Каудерийг би хүссэн зүгтээ илгээж болохын тулд түүнд бичээч болох хэн нэгэн байхгүй үед түүнд бичээч болох ёстой.

7 Мөн миний Сүнсээр чамд өгөгдсөний дагуу, чи судруудыг тайлбарлах, мөн сүмд ухуулахын тулд түүний гарын дор “томилогдох ёстой.

8 Учир нь тэрээр чиний дээр “гараа тавих болно, мөн чи Ариун Сүнсийг хүлээн авах болно, мөн цаг хугацаа чинь бичих хийгээд ихийг сурахад зориулагдах ёстой.

9 Мөн чи эмээх хэрэггүй, учир нь нөхөр чинь чамайг

25 1a Иохан 1:12.

су Бурханы хөвгүүд охид.

б су Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс.

2a су Нөлөөлөх хүч.

б су Аллах, Бурхан-

тай хамт алхах.

в С ба Г 52:42; 64:30; 101:18.

су Сион.

3a Мат. 9:2.

б су Дуудах, Бурханаас дуудагдах, Дуудлага.

5a су Өрөвч сэтгэл.

7a эсвэл Томилон адислах.

су Онцгойлон адислах.

8a су Гар тавих.

сүмд дэмжих болно; учир нь тэдний итгэлийн дагуу миний хүссэн бүх зүйлүүд тэдэнд “илчлэгдэж болохын тулд түүний ^бдуудлага тэдний төлөө байдаг билээ.

10 Мөн чи энэ “дэлхийн ^бзүйлүүдийг хойш тавьж, мөн илүү сайн зүйлүүдийг ^сэрэлхийлэх ёстой гэдгийг би чамд үнэнээр хэлж байна.

11 Мөн миний сүмд байх, тэрчлэн, намайг баярлуулах сүмийн ариун “дууллууд чамд өгөгдсөнчлөн, түүвэр хийх нь чамд өгөгдөх болно.

12 Учир нь “зүрх сэтгэлийн ^бдуунд сүнс минь баярлах авай; тийм ээ, зөв шударгыг үйлдэгчдийн дуу нь надад хандсан залбирал бөлгөө, мөн энэ нь тэдний тэргүүн

дээр адислалаар хариулагдах болно.

13 Иймийн тул, зүрх сэтгэлээ өргөж мөн баясагтун, мөн хийсэн гэрээнүүдээ итгэлтэйгээр сахигтун.

14 Номхон “дөлгөөн байдлын сүнсэнд үргэлжлүүл, мөн ^ббардамналаас болгоомжил. Нөхөртөө, мөн түүнд ирэх алдар сууд сүнс чинь баярлаг.

15 Миний зарлигуудыг байнга сахигтун, мөн “зөв шударга ёсны ^бтитмийг чи хүлээн авах болно. Мөн чи үүнийг үйлдэхээс бусдаар, миний байгаа энд чи ирж ^счадах нь үгүй.

16 Мөн үнэнээр, үнэнээр би чамд хэлж байна, энэ бол бүгдэд хандах миний “дуу хоолой болой. Амен.

ХЭСЭГ 26

1830 оны долдугаар сард Пеннсильванийн Хармонид Бошиглогч Иосеф Смит, Оливер Каудери, мөн Жон Витмер нарт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:104). (Хэсэг 24-ийн толгой гарчгийг үз.)

1, Тэд судруудыг судалж мөн номлохоор зааварлагдав; 2, Нийтийн дэмжлэгийн хууль батлагдав.

БОЛГООГТУН, дараагийн Чуулганыг хийхээр өрнөд

уруу та нар явах хүртлээ судруудыг ^ссудлах, мөн номлох, мөн ^бКоллесвиллд сүмийг батлах, мөн шаардагдсаны дагуу уг нутагт өөрсдийн хөдөлмөрүүдийг гүйцэтгэхэд, та нар цаг заваа зориулагтун

9а су Бошиглох,
Бошиглол;
Илчлэлт.
б су Дуудах,
Бурханаас
дуудагдах,
Дуудлага;
Бошиглогч.
10а су Дэлхийнх.
б су Шунах;

Баялгууд.
в Ифер 12:4.
11а су Дуулал.
12а су Зүрх.
б Шаст. дээд 16:9.
су Дуулах.
14а су Номхон
дөлгөөн, Номхон
дөлгөөн байдал.
б су Бардамнал.

15а су Зөв шударга,
Зөв шударга ёс.
б су Титэм;
Өргөмжлөл.
в Иохан 7:34.
16а С ба Г 1:38.
26 1а С ба Г 24:3; 37:2.
б су Судрууд—
Судруудын үнэ
цэнэ.

хэмээн би та нарт хэлж байна; мөн тэгэхэд та нарт юу хийх ёстой нь мэдүүлэгдэх болно.

2 Мөн сүмд бүх зүйл сүмийн

“нийтийн дэмжлэгээр маш их залбирал хийгээд итгэлээр хийгдэх болно, учир нь бүх зүйлүүдийг та нар итгэлээр хүлээж авах болно. Амен.

ХЭСЭГ 27

1830 оны наймдугаар сард Пеннсилванийн Хармонид Бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:106–108). Талх болон дарсны ариун ёслолыг гүйцэтгэх шашны үйлчлэлийг бэлтгэхэд Иосеф дарс авчрахаар явав. Тэрээр тэнгэр элчтэй уулзаж, нэг хэсгийг нь тэр үед, мөн үлдсэнийг нь дараагийн есдүгээр сард бичсэн энэхүү илчлэлтийг хүлээн авчээ. Эдүгээ Сүмийн ариун ёслолын үйлчлэлүүдэд дарсны оронд ус хэрэглэдэг болов.

1–4, Ариун ёслолоос хүртэхэд хэрэглэгдэх бэлэгдлүүд тайлбарлагдав; 5–14, Христ болон бүх эрин үеийн түүний үйлчлэгчид ариун ёслолоос хүртэх болно; 15–18, Бурханы өвч хуяг дуулгыг өмсөгтүн.

АНХААРАГТУН, үг нь “амьд бөгөөд хүчирхэг өөрийн Их Эзэн, Есүс Христ, өөрийн Бурхан, мөн өөрийн Гэтэлгэгчийн дуу хоолойг.

2 Учир нь, болгоогтун, би та нарт хэлж байна, хэрэв та нар үүнийг миний “алдар суугийн төлөө бүхнээ зориулснаар та нарын төлөө унасан миний бие хийгээд та нарын нүглүүдийн ^бангжралын төлөө асгарсан миний ^вцусыг эцэгт минь дурсан үйлдэх аваас, ^гариун ёслолоос хүртэхдээ та нар юу идэх

буюу юу уух нь хамаагүй хэрэг билээ.

3 Иймийн тул, та нар дарсыг ч, бас хүчтэй ундааг ч дайснаудаасаа худалдаж авахгүй байх ёстой хэмээх зарлигийг би та нарт өгч байна;

4 Иймийн тул, та нарын дунд энэ нь шинээр хийгдэхээс бусдаар, тийм ээ, дэлхий дээр өсөн бэхжих миний Эцэгийн энэ хаант улсад та нар өөр юуг ч хүртэх ёсгүй.

5 Болгоогтун, энэ бол надад орших мэргэн ухаан болой; иймийн тул, бүү гайх, учир нь би та нарын хамт, мөн миний үүрдийн бүрэн сайн мэдээг агуулсан Мормоны Номыг та нарт илчлэхээр миний илгээсэн, Ефраимын “савааны цэдгийн түлхүүрүүдийг миний итгэмжилсэн ^бМоронайн хамт дэлхий дээр

2a 1 Сам. 8:7;
Мозая 29:26.
сү Нийтийн
дэмжлэг.

27 1a Хил. 3:29;
С ба Г 6:2.

2a сү Алдар суу.
б сү Нүглүүдийн
ангжрал.
в сү Цус.
г сү Ариун ёслол.
5a Езек. 37:16.

сү Ефраим—
Ефраимын буюу
Иосефын Саваа.
б ИС—Т 1:30–34.

усан үзмийн модны жимс-
нээс “уух цаг ирнэ;

6 Мөн тэрчлэн дэлхий
эхэлсэн цагаас хойш бүх
ариун бошиглогчдын амаар
хэлэгдсэн эцсийн өдрүүдийн
талаарх бүх зүйлүүдийн да-
хин сэргэлтийг улируулан
тохиолгохоор авчрах түлхүү-
рүүдийг миний итгэмжил-
сэн “Елиатай хамт буюу;

7 Мөн, тэрээр “(Елиа) За-
хариатай уулзаж тэрбээр
хүүтэй болно, мөн түүний
нэр нь Иохан байх болно,
бас тэрбээр Елиасын сүнсээр
дүүргэгдэх болно хэмээх ам-
лалтыг өгсөн, мөнөөх Заха-
риагийн хүү ^бИохантай буюу;

8 Та нар бүр “Аароны адил
дуудагдаж, мөн ^бтомилог-
дож болохын тулд, та нарын
хүлээн авсан тэрхүү анхны
“санваарт та нарыг томило-
хоор миний үйлчлэгч Бага
Иосеф Смит, Оливер Кауде-
ри та хоёрт миний илгээсэн
мөнөөх Иохан буюу.

9 Мөн тэрчлэн, бүхэл дэлхий
зүхлээр цохигдохгүйн тулд
эцгүүдийн зүрхийг хүүхдүүд
уруу нь, мөн хүүхдүүдийнх
нь зүрхийг эцгүүд уруу нь

“эргүүлэх хүчний түлхүүрүү-
дийг миний түүнд итгэм-
жилсэн ^бЕлиатай болой;

10 Мөн тэрчлэн амлалтууд
дамжин “үлддэг та нарын
эцгүүд, Иосеф болон Иаков,
мөн Исаак, мөн Абрахамтай
хамт буюу;

11 Мөн тэрчлэн бүхний эцэг,
бүхний хунтайж, эртний нэг-
гэн, Михаил буюу “Адамтай
хамт буюу;

12 Мөн та нарт миний ил-
гээсэн, мөн та нарыг “төлөө-
лөгчид мөн миний нэрний
тусгай ^бгэрчүүд байхаар, мөн
та нарын тохинууллын хий-
гээд тэдэнд миний илчилсэн
тэрхүү зүйлүүдийн түлхүү-
рүүдийг авч явахаар та на-
рыг бибээр тэднээр ^бтомилж
мөн баталсан Иохан, Петр,
мөн Иаковтай тэрчлэн хамт
буюу;

13 Бибээр өөрийн хаант
улсын “түлхүүрүүдийг, мөн
^бэцсийн үеүдэд зориулсан
“сайн мэдээний ‘эрин үеийг
тэдэнд ^битгэмжилсэн бөлгөө;
мөн бүх зүйлүүдийг, тэнгэр
дэх, мөн дэлхий дээрх аль
алиныг нь бибээр ^бнэгд
хамтад нь цуглуулах цаг

5в Мат. 26:29;
Марк 14:25;
Лук 22:18.

6а су Елиа.

7а Лук 1:17–19.

б Лук 1:13;
С ба Г 84:27–28.

8а Ег. 28:1–3, 41;
С ба Г 107:13.

б су Томилох,
Томилолт.

в С ба Г 13:1.
су Аароны

санваар.

9а су Удмын бичиг.

б Хаад. дээд 17:1–22;

Хаад. дэд 1–2;

С ба Г 2:1–3;

110:13–16;

ИС—Т 1:38–39.

су Елиа; Удмын
бичиг.

10а су Абрахамын
гэрээ.

11а су Адам.

12а су Төлөөлөгч.

б Үйлс 1:8.

в ИС—Т 1:72.

су Мелкизедек
санваар.

13а су Санваарын
түлхүүрүүд.

б Иаков 5:71;

С ба Г 43:28–30.

в су Сайн мэдээ.

г су Эрин үе.

д Мат. 16:19.

е С ба Г 84:100.

хугацааны ^абүрэн байдлын тулд буюу;

14 Мөн тэрчлэн дэлхийгээс Эцэгийн минь надад ^аөгсөн тэд бүгдтэй хамт буюу.

15 Иймийн тул, бүхнийг хийснээр, та нар муу ёрын өдрийг тэсвэрлэн, та нар ^атэсч гарах боломжтой байхын тулд зүрх сэтгэлээ өргөж мөн баясагтун, мөн хормойгоо шуу, мөн миний ^бөвч хуяг дуулгыг өөрсөд дээрээ авагтун.

16 Босогтун, тиймийн тул, ^аүнэнээр ^ббүсээ чанга бүсэлж, ^сзөв шударга ёсны ^дхуягийг өмсөн, мөн бибээр та нарт итгэмжлэхээр ^етэнгэр элчүүдээ илгээсэн ^аамар амгалан-

гийн сайн мэдээний бэлтгэлийг хөлдөө өмсөгтүн;

17 Ёсон бусчуудын бүхий л ^агалт сумнуудыг та нар унтраах боломжтой байх итгэлийн тэрхүү бамбайг гартаа аван;

18 Мөн авралын дуулгыг, мөн та нар дээр миний юүлэх Сүнсний минь илдийг, мөн та нарт илчлэх миний үгийг авагтун, мөн надаас асуух бүхий л зүйлсийн талаар та нар санал нэгтэй байгтун, мөн намайг иртэл та нар итгэлтэй байгтун, мөн та нар ^ааваачигдах болно, ингэснээр миний байгаа тэнд та нар ^бтэрчлэн байх болно. Амен.

ХЭСЭГ 28

1830 оны есдүгээр сард Нью-Йоркийн Фейеттэд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Оливер Каудерид өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:109–111). Сионыг байгуулах болон Сүмийн дэг жаягийн талаарх илчлэлтүүдийг үүний тусламжтайгаар хүлээн авдаг хэмээсэн нэгэн чулуу Сүмийн гишүүн Хайрам Пейжид байжээ. Хэд хэдэн гишүүн эдгээр мэдэгдэлд мэхлэгдэж, мөн тэр ч байтугай Оливер Каудери хүртэл үүгээр буруу нөлөөлөгдсөн байлаа. Товлосон нэгэн чуулганы өмнөхөн Бошиглогч уг асуудлын талаар Их Эзэнээс үнэнхүү сэтгэлээр асууж, мөн энэхүү илчлэлт иржээ.

1–7, Иосеф Смит нууцуудын түлхүүрүүдийг атгадаг, мөн зөвхөн тэрбээр Сүмд зориулсан илчлэлтүүдийг хүлээн авдаг; 8–10, Оливер Каудери лемен-

чүүдэд номлох ёстой; 11–16, Сатан Хайрам Пейжийг мэхэлж мөн түүнд хуурамч илчлэлтүүдийг өгчээ.

13^ё Ефес 1:9–10;
С ба Г 112:30; 124:41.

14^а Иохан 6:37; 17:9, 11;
3 Ниф. 15:24;
С ба Г 50:41–42;
84:63.

15^а Малах. 3:2;
С ба Г 87:8.

б Ром 13:12;
Ефес 6:11–18.

16^а су Үнэн.
б Иса. 11:5.
в су Зөв шударга,
Зөв шударга ёс.
г Иса. 59:17.
д С ба Г 128:19–21.

е 2 Ниф. 19:6.
17^а 1 Ниф. 15:24;
С ба Г 3:8.

18^а 1 Ниф. 13:37;
С ба Г 17:8.
б Иохан 14:3.

БОЛГООГТУН, “Оливер чамд би хэлж байна, миний өгсөн илчлэлтүүд хийгээд зарлигуудын талаар тэдэнд ⁶Тайтгаруулагчаар чиний “заах аливаа бүх зүйлд сүм чамайг сонсдог байх нь чамд өгөгдөх болно.

2 Гэвч, болгоогтун, үнэнээр, үнэнээр би чамд хэлнэ, миний үйлчлэгч Бага “Иосеф Смитээс өөр ⁶хэн ч энэ сүмд зарлигууд хийгээд илчлэлтүүдийг хүлээн авахаар томилогдох нь үгүй, учир нь тэрбээр бүр Мосегийн адилаар тэдгээрийг хүлээн авдаг болой.

3 Мөн түүнд миний өгөх тэр зүйлүүдэд, зарлигууд хийгээд илчлэлтүүдийг, хүч хийгээд сүмд “эрх мэдэлтэйгээр, итгэлтэйгээр тунхаглахад чи бүр ⁶Аароны адил дуулгавартай байх ёстой.

4 Мөн хэрэв чи аливаа нэг үед эсвээс бүх цагт сүмд зарлигийн замаар “ярих буюу заахаар Тайтгаруулагчаар хөтлөгдөх аваас, чи үүнийг хийж болно.

5 Гэвч чи зарлигийн замаар бичих ёстой бус, харин мэргэн ухаанаар болой;

6 Мөн чиний тэргүүнд, мөн сүмийн тэргүүнд байгаа түүнд чи зарлиглах ёсгүй;

7 Учир нь түүний оронд би

тэдэнд өөр нэгнийг томилох хүртэл “нууцуудын ⁶түлхүүрүүдийг мөн лацлагдсан тэдгээр илчлэлтүүдийг бибээр түүнд өгсөн билээ.

8 Мөн эдүгээ, болгоогтун, чи “леменчүүд уруу очиж, мөн миний ⁶сайн мэдээг тэдэнд заах ёстой гэдгийг би чамд хэлнэ; мөн тэд чиний заасан зүйлүүдийг хүлээн авахын хэрээр чи миний сүмийг тэдний дунд байгуулагдахаар болгох ёстой; мөн чи илчлэлтүүдийг хүлээн авах болно, гэвч тэдгээрийг зарлигийн замаар бүү бич.

9 Мөн эдүгээ, болгоогтун, “Сион ⁶хот хаана баригдсан байхыг ямар ч хүмүүн мэдэхгүйг, мөн энэ нь илчлэгдээгүйг би чамд хэлж байна, гэвч энэ нь үүнээс хойш өгөгдөх болно. Болгоогтун, энэ нь леменчүүдийн ойролцоох хил дээр байх болно гэдгийг би чамд хэлж байна.

10 Чуулганы дарааг хүртэл чи энэ газрыг орхин явах ёсгүй; мөн миний үйлчлэгч Иосеф үүний дуу хоолойгоор чуулганыг тэргүүлэхээр томилогдох ёстой, мөн чамд тэрээр юу хэлнэ, чи хэлэх ёстой.

11 Мөн дахин, чи өөрийн ах Хайрам Пейжтэй “ганцаарчлан уулзах ёстой, мөн уг

28 1a С ба Г 20:3.
б су Тайтгаруулагч.
в су Заах, Багш—
 Сүнсээр Заах.
 2a 2 Ниф. 3:14–20.
 су Бага Иосеф
 Смит
б С ба Г 35:17–18; 43:4.

3a су Эрх мэдэл.
б су Аарон,
 Мосегийн ах.
 4a Ег. 4:12–16;
 С ба Г 24:5–6.
 7a су Бурханы
 нууцууд.
б С ба Г 64:5; 84:19.

8a 2 Ниф. 3:18–22;
 С ба Г 30:5–6; 32:1–3.
б С ба Г 3:19–20.
 9a С ба Г 52:42–43.
 су Сион.
б С ба Г 57:1–3.
 11a Мат. 18:15.

чулуунаас түүний бичиж авсан тэдгээр зүйлс нь надаас бус гэдгийг, мөн ⁶Сатан түүнийг ⁶мэхэлж буйг түүнд хэлэгтүн;

12 Учир нь, болгоогтун, эдгээр зүйлүүд түүнд өгөгдсөн нь үгүй, түүнчлэн сүмийн гэрээнүүдэд харшлах ямар ч зүйл энэ сүмийн аль ч гишүүнд өгөгдөх нь үгүй бөлгөө.

13 Учир нь сүмд бүх зүйлс эмх цэгцэд, мөн “нийтийн дэмжлэгээр, итгэлийн

залбирлаар хийгддэг байх ёстой.

14 Мөн леменчүүдийн дунд чи аялахаасаа өмнө, чи эдгээр бүх зүйлийг сүмийн гэрээнүүдийн дагуу зохицуулахад туслах ёстой.

15 Мөн чиний явах тэр цагаас, чиний буцаж ирэх тэр цагийг хүртэл юу хийх чинь чамд “өгөгдөх болно.

16 Мөн чи миний сайн мэдээг баяслын дуугаар тунхаглан, ам чинь бүх цаг үед нээлттэй байх ёстой. Амен.

ХЭСЭГ 29

1830 оны есдүгээр сард Нью-Йоркийн Фейеттед зургаан ахлагчийн дэргэд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:111–115). Энэхүү илчлэлт 1830 оны есдүгээр сарын 26-нд эхэлсэн чуулганаас хэд хоногийн өмнө өгөгджээ.

1–8, Христ өөрийн сонгосон хүмүүсийг цуглуулдаг; 9–11, Түүний ирэлт Мянганыг эхлүүлнэ; 12—13, Арванхоёр нь бүх Израилыг шүүх болно; 14–21, Тэмдгүүд, өвчин тахлууд, эзгүйрлүүд Хоёр дахь Ирэлтийн өмнө тохиох болно; 22–28, Мянганы дараа сүүлчийн амилуулалт хийгээд эцсийн шүүлт болно; 29–35, Их Эзэний хувьд бүх зүйл сүнслэг болой; 36–39, Чөтгөр болон түүний арми хүмүүнийг уруу татахын тулд тэнгэрээс зайлуулагдсан билээ; 40–45, Уналт болон Цагаатгал нь

авралыг авчирдаг; 46–50, Бага насны хүүхдүүд цагаатгалаар дамжин гэтэлгэгддэг.

АНХААРАГТУН, та нарын АГэтэлгэгч, та нарын нүглүүдийг “нигүүлслийн мутар нь ⁶цагаатгасан Агуу ⁶Би байдаг, Есүс Христийн дуу хоолойг буюу;

2 Бүр миний дуу хоолойг сонсох мөн өөрсдийгөө миний өмнө “даруусгах, мөн хүчирхэг залбиралд намайг дуудах болгоныг, тахиа дэгдээхийнүүдээ далавчин дороо цуглуулдаг шиг

116 Илч. 20:10.
в С ба Г 43:5–7.
13а су Нийтийн дэмжлэг.

15а 2 Ниф. 32:3, 5.
29 1а су Нигүүлсэнгүй, Нигүүлсэл.
б су Цагаатгах,

Цагаатгал.
в су БИ БАЙДАГ.
2а су Даруу, Даруу байдал.

өөрийнхөө хүмүүсийг ^бцуглуулах намайг.

3 Болгоогтун, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, энэ үед нүглүүд тань та нарт “өршөөгдсөн болой, тиймийн тул та нар эдгээр зүйлүүдийг хүлээн авч байна; гэхдээ санагтун, аюул та нарын дээр ирэхгүйн тулд дахиад нүгэл үйлдэхгүй байхыг санагтун.

4 Үнэнээр, би та нарт хэлж байна, та нар бол миний сайн мэдээг баяслын дуугаар, “бүррэн дуу хоолой мэт тунхаглахаар дэлхийгээс сонгогдсон билээ.

5 Зүрх сэтгэлээ өргөж мөн баяртай байгтун, учир нь би та нарын “дунд байна, мөн бибээр Эцэгийн өмнө та нарын ^бөмгөөлөгч билээ; мөн та нарт “хаант улсыг өгөх нь түүний эрхэм таалал бөлгөө.

6 Мөн, энэ нь бичигдсэний адилаар—Миний зарлигийн дагуу залбиралд “нэгдсэн байх аваас, та нар ^битгэлд юу ч “хүслээ гэсэн, та нар хүлээн авах болно.

7 Мөн та нар миний “сонгосон хүмүүсийн ^бцугларалтыг

тохиолгон авчрахаар дуудагдсан билээ; учир нь миний сонгосон хүмүүс дуу хоолойг минь ^ссонсож мөн зүрх сэтгэлээ “хатууруулах нь үгүй;

8 Иймийн тулд ёсон бусчууд дээр “гай зовлон болон эзгүйрэл илгээгдэх тэр өдөрт зүрх сэтгэлээ ^ббэлтгэж мөн бүх зүйлд бэлтгэгдсэн байхаар тэд энэ нутгийн нүүрэн дээр нэг газарт ^сцугларах болно хэмээх тогтоол нь Эцэгээс урагш гарч ирсэн билээ.

9 Учир нь дэлхий боловсорч гүйцэх тэр цаг ойрхон байна мөн тэр өдөр мөдхөн байна; мөн бүх “бардамнагчид мөн ёс бусаар үйлдэх тэд ^бталбайд хаягдсан сүрэл лугаа адил болох болно; мөн дэлхий дээр ёс бус явдал байхгүй байхын тулд бибээр тэднийг “шатаах болно хэмээн Түмэний Их Эзэн өгүүлнэм;

10 Учир нь тэр цаг ойрхон байна, мөн миний төлөөлөгчдөөр “хэлэгдсэн нь биелэгдэх ёстой; учир нь тэдний ярьсанчлан энэ нь улиран тохиох болно;

2б Мат. 23:37;

3 Ниф. 10:4–6.

3а су Уучлах.

4а Алма 29:1–2;

С ба Г 19:37; 30:9.

5а Мат. 18:20;

С ба Г 6:32; 38:7;

88:62–63.

б су Өмгөөлөгч.

в су Бурханы хаант

улс буюу

Тэнгэрийн хаант

улс.

6а 3 Ниф. 27:1–2;

С ба Г 84:1.

б Марк 11:24.

в Мат. 21:22;

Иохан 14:13.

7а Марк 13:20;

С ба Г 84:34.

су Сонгох.

б су Израил—

Израилын

цугларалт.

в Алма 5:37–41.

г су Зүрх.

8а С ба Г 5:19; 43:17–27.

б С ба Г 58:6–9; 78:7.

в С ба Г 45:64–66; 57:1.

9а 2 Ниф. 20:33;

3 Ниф. 25:1.

су Бардамнал.

б Нахум 1:10;

Малах. 4:1;

1 Ниф. 22:15, 23;

ИС—Т 1:37.

в С ба Г 45:57; 63:34,

54; 64:24; 88:94;

101:23–25; 133:64.

су Дэлхий—

Дэлхийн

цэвэршилт.

10а су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

11 Учир нь би тэнгэрээс үүний бүх “олны хамт сүр хүч хийгээд агуу алдар суугаар өөрийгөө үзүүлэх болно, мөн дэлхий дээр “зөв шударга ёсонд хүмүүнтэй хамт “мянган жил оршин сууна, мөн ёс бусыг үйлдэгчид тэсвэрлэх нь үгүй бөлгөө.

12 Мөн дахин, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, миний “төлөөлөгчид, Иерусалимд миний тохинуулалд надтай хамт байсан тэр Арванхоёр, “галан багананд миний ирэх тэр өдөр баруун гар талд минь зөв шударгын орхимжоор хувцаслан, тэргүүн дээрээ титэмтэйгээр, өөр хэнийг ч бус Израилын бүх угсааг, бүр намайг хайрлаж мөн зарлигуудыг минь сахидаг тэдгээр олныг “шүүхээр миний нэгэн адил ‘алдар сууд зогсох болно гэдэг нь чанд хатуу тогтоолоор, Эцэгийн тааллаар урагш гарч ирсэн бөлгөө.

13 Учир нь “бүрээ чанга хийгээд удаан аль алинаар нь бүр Синайн Уулан дээр мэт дуугарах болно, мөн бүх газар хөдлөх болно — тийм ээ, бид

нэг байж болохын тулд бүр надад нас барсан тэрхүү “талийдгаачид, “бүр миний нэгэн адил зөв шударгын ‘титмийг хүлээн авч мөн хувцаслаж, надтай хамт байхаар тэд “урагш гарч ирэх болно.

14 Гэвч, болгоогтун, энэхүү агуу “өдөр ирэхийн өмнө “нар харанхуйлж, мөн сар цус болон хувирч, мөн одод тэнгэрээс унах болно, мөн дээр тэнгэрт хийгээд доор газарт илүү агуу “тэмдгүүд байх болно гэдгийг би та нарт хэлж байна;

15 Мөн олны дунд уйлаан хийгээд “ёолон гаслах нь байх болно;

16 Мөн дэлхийн ургацыг устгахын тулд агуу “мөндрөн шуурга урагш илгээгдэх болно.

17 Мөнхүү улиран тохиох дор, дэлхийн ёсон бусын учир, бибээр “ёс бусчууд дээр “ёс хонзон тохиолгох болно, учир нь тэд наманчлах нь үгүй; учир нь миний зэвүүцлийн аяга дүүрэн байна; учрыг болгоогтун, хэрэв тэд намайг эс сонсоос, миний

11a ИС—А 1:37.

б су Зөв шударга,
Зөв шударга ёс.

в су Есүс Христ—
Христийн Мянган
жилийн хаанчлал;
Мянган жил.

12a су Төлөөлөгч.

б Иса. 66:15–16;
С ба Г 130:7; 133:41.

в Мат. 19:28;
Лук 22:30;
1 Ниф. 12:9;
Морм. 3:18–19.

г су Алдар суу;
Есүс Христ—Есүс
Христийн алдар
суу.

13a С ба Г 43:18; 45:45.
б С ба Г 88:97; 133:56.
в С ба Г 76:94–95;
84:35–39.

г су Титэм;
Өргөмжлөл.
д С ба Г 76:50.

14a су Есүс Христийн
Хоёр дахь Ирэлт.
б Иеол 2:10;

ИС—А 1:33.

в су Цаг хугацааны
тэмдгүүд.

15a Мат. 13:42.

16a Езек. 38:22;
Илч. 11:19; 16:21.

17a су Ёс бус, Ёс бус
байдал.

б Илч. 16:7–11;
2 Ниф. 30:10;
ИС—А 1:53–55.
су Өс хонзон.

⁶цус тэднийг цэвэршүүлэх нь үгүй болой.

18 Иймийн тул, Их Эзэн Бурхан бибээр дэлхийн нүүрэн дээр оршин суугчдыг нь эзлэн авч мөн тэдний махан биеийг идэх ялаануудыг урагш илгээх болно, мөн махчин өтнүүдийг тэдэн дээр ирэхээр болгоно;

19 Мөн тэдний хэл гацаагдах болно, ингэснээр тэд миний эсрэг “үг дуугарахгүй байх болно; мөн тэдний махан бие яснаасаа мултарч мөн тэдний нүд ухархайнаасаа мултарч унах болно;

20 Мөнхүү улиран тохиох дор “ойн араатнууд хийгээд огторгуйн жигүүртнүүд тэднийг идэж дуусгах болно.

21 Мөн ирээгүй хэдий ч, би амьдардгийн адилаар гарцаагүй тохиох “ёстой эдгээр зүйлүүдийг ярьсан бошиглогч Езекиелийн амаар хэлэгдсэний дагуу бүх дэлхийн ⁶садар эм болох тэрхүү агуу хийгээд ⁶жигшүүрт сүм ‘устгагч галаар доош шидэгдэх болно, учир нь жигшүүрт явдал ноёрхох нь үгүй.

22 Мөн дахин, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ,

“мянган жил дуусахад мөн хүмүүн Бурханаа дахин үгүйсгэж эхэлнэ, тэгэхэд бибээр дэлхийд өршөөнгүй хандах болно, гэхдээ ⁶богинохон хугацаанд буюу;

23 Мөн “төгсгөл ирэх болно, мөн тэнгэр хийгээд дэлхий устгагдаж тэгээд ⁶алга болох авай, мөн шинэ тэнгэр бас ⁶шинэ дэлхий байх болно.

24 Учир нь бүх хуучин зүйл “алга болж, мөн бүх зүйл, бүр тэнгэр хийгээд газар бас тэдгээрийн бүрэн байдал, хүмүүн хийгээд амьтад аль аль нь, огторгуйн жигүүртнүүд, мөн далайн загаснууд ч шинэ болно;

25 Мөн нэг ширхэг “үс ч, бас өчүүхэн зүйл ч гээгдэх нь үгүй, учир нь энэ нь миний гарын бүтээл бөлгөө.

26 Гэвч, болгоогтун, үнэнээр би та нарт хэлнэ, дэлхий алга болохын өмнө, миний “тэргүүн тэнгэр элч, ⁶Михаил ⁶бүрээгээ үлээх болно, мөн тэгэхэд бүх нас барагсад ⁶сэрэх болно, учир нь тэдний булшнууд нээгдэх болно, мөн тэд—тийм ээ, бүр бүгдээрээ ⁶урагш гарч ирэх болно.

17в 1 Иохан 1:7;
Алма 11:40–41;
С ба Г 19:16–18.

19а Зех. 14:12.

20а Иса. 18:6;
Езек. 39:17;
Илч. 19:17–18.

21а С ба Г 1:38.
б Илч. 19:2.

в су Чөтгөр—
Чөтгөрийн сүм.
г Иоел 1:19–20; 2:3;
С ба Г 97:25–26.

су Дэлхий—
Дэлхийн
цэвэршилт.
22а су Мянган жил.

б Илч. 20:3;
С ба Г 43:30–31;
88:110–111.

23а Мат. 24:14.
су Дэлхий—
Дэлхийн төгсгөл.
б Мат. 24:35;
ИС—А 1:35.
в су Дэлхий—

Дэлхийн эцсийн
байдал.

24а Илч. 21:1–4.

25а Алма 40:23.

26а су Тэргүүн тэнгэр
элч.

б су Адам; Михаил.
в 1 Кор. 15:52–55.

г су Мөнх бус, Мөнх
бус байдал;
Амилуулалт.

д Иохан 5:28–29.

27 Мөн “зөв шударгыг үйлдэгчид мөнх амьдралд миний ^ббаруун гар талд цугларах болно; мөн миний зүүн гар тал дахь ёс бусыг үйлдэгчдийг өмчлөхөөс би Эцэгийн өмнө ичих болно;

28 Иймийн тул бибээр тэдэнд хэлэх болно—“Чөтгөр болон түүний элчүүдэд бэлтгэгдсэн үүрдийн ^бгал уруу, надаас “зайлагтун, зүхэгдсэн та нар.

29 Мөн эдүгээ, болгоогтун, би та нарт хэлнэ, тэд эргэж ирэх ёстой хэмээн би өөрийн амаар хэзээ ч ямар ч цаг үед тунхаглаагүй бөлгөө, учир нь миний “байгаа тэнд тэд очиж чадахгүй, учир нь тэдэнд хүч байхгүй бөлгөө.

30 Харин миний бүх шүүлтүүд хүмүүнд өгөгдөөгүйг санагтун; мөн “эхнийх нь эцсийнх байхын тулд, мөн миний Сүнсний хүч болох өөрийн сүр хүчний үгээр би юу ч бүтээсэн байлаа гэсэн бүх зүйлд эцсийнх нь эхнийх байхын тулд миний амнаас үгс урагш гарсан л бол бүр тийнхүү тэдгээр нь биелэгдэх болно.

31 Учир нь би тэдгээрийг, тийм ээ, “сүнсний хийгээд материаллаг бүх зүйлүүд аль алиныг нь Сүнснийхээ хүчээр ^ббүтээсэн билээ—

32 Миний ажлын эхлэл нь,

эхнийх нь “сүнслэг, хоёр дахь нь материаллаг болой; мөн дахин, миний ажлын төгсгөл нь, эхнийх нь материаллаг, мөн хоёр дахь нь сүнслэг болой—

33 Та нар өөрсдийнхөөрөө ойлгож болохын тулд та нарт өгүүлнэм; харин миний хувьд миний ажлууд “төгсгөлгүй, мөн эхлэлгүй бөлгөө; гэвч та нар ойлгож болохын тулд үүнийг надаас асууж мөн санал нэгтэй байгаа учраас энэ нь та нарт өгөгдсөн билээ.

34 Иймийн тул, бүх зүйл миний хувьд сүнслэг юм гэдгийг би та нарт үнэнээр хэлнэ, мөн аль ч цаг үед би та нарт, бас ямар ч хүнд, эсвээс хүмүүний үрст, мөн өөрийн бүтээсэн та нарын эцэг Адамд ч, цаг зуурын хууль өгөөгүй бөлгөө.

35 Болгоогтун, тэрээр “өөрийнхөө төлөө сонгогч байхыг нь би түүнд өгсөн юм; мөн би түүнд зарлиг өгсөн буюу, гэвч би түүнд цаг зуурын зарлиг өгсөн нь үгүй, учир нь миний ^бзарлигууд сүнслэг болой; тэдгээр нь ердийн ч бус, цаг зуурын ч биш, зуурдынх ч биш, хүсэл тачаангуй ч биш бөлгөө.

36 Мөнхүү улиран тохиох дор Адам чөтгөрөөр уруу татагдсан байв—учир нь,

27a су Зөв шударга,
Зөв шударга ёс.
б Мат. 25:33.
су Эцсийн шүүлт.
28a су Чөтгөр.
б С ба Г 43:33.
в Мат. 25:41;

С ба Г 29:41.
29a Иохан 7:34;
С ба Г 76:112.
30a Мат. 19:30;
1 Ниф. 13:42.
31a Моце 3:4–5.
б су Бүтээх, Бүтээл.

32a су Сүнсний бүтээл.
33a Дуул. 111:7–8;
Моце 1:4.
35a су Сонгох эрх.
б су Бурханы
зарлигууд.

болгоогтун, “чөтгөр Адамаас өмнө байлаа, учир нь, ^бсүр хүч тань болох ^аалдар хүндэтгэлээ надад өг хэмээн тэрээр хэлж, миний эсрэг ^вбоссон бөлгөө, мөн тэрчлэн тэдний ^дсонгох эрхийн улмаас тэнгэрийн ^еолны ^жгуравны нэг хэсгийг тэрээр надаас урвуулсан билээ;

37 Мөн тэд доош хөөгдсөн юм, мөн тийн “чөтгөр хийгээд түүний ^бэлчүүд болсон бөлгөө;

38 Мөн, болгоогтун, эхлэлээс тэдэнд бэлтгэсэн нэгэн газар буй нь ^атам юм.

39 Мөн чөтгөр хүмүүний үрсийг ^ауруу татах ёстой нь шаардлагатай ажгуу, эс бөгөөс тэд өөрсдийнхөө төлөө сонгогч байж эс чадна; учир нь хэрэв ^бгашуун нь тэдэнд хэзээ ч байх ёсгүй аваас, тэд чихэрлэгийг мэдэж чадах нь үгүй бөлгөө—

40 Иймийн тул, мөнхүү улиран тохиох дор чөтгөр Адамыг уруу татаж, мөн тэрээр хориглогдсон ^ажимснээс хүртэж мөн зарлигийг зөрчсөн нь, тэрээр уруу татал-

танд автагдсан учир ийнхүү чөтгөрийн таалалд ^бзахирагдсан бөлгөө.

41 Иймийн тул, Их Эзэн Бурхан бибээр, түүний зөрчлийн учир түүнийг ^аЕденгийн Цэцэрлэгээс, өөрийнхөө дэргэдээс ^бхөөгдөх ёстой болгосон билээ, үүгээр тэрээр ^всүнсний хувьд үхмэл болсон нь, намайг: Зайлагтун, ^гзүхэгдсэн та нар хэмээн хэлэх үед ёс бусыг үйлдэгчид дээр тохиох тэрхүү сүнсний, бүр сүүлчийн ^дүхэл болох тэрхүү үхэлтэй адил үхэл болох анхны үхэл юм.

42 Гэвч, болгоогтун, Их Эзэн Бурхан бибээр, миний Төрсөн ^аГанц Хүүгийн нэрэн дээрх итгэлээр дамжин ирэх ^бнаманчлал хийгээд ^ггэтэлгэлийг тэдэнд тунхаглахаар ^дтэнгэр элчүүдийг урагш илгээх хүртэл тэд цаг зуурын үхлээр ^еүхэх ёсгүйг Их Эзэн Бурхан бибээр Адам хийгээд түүний үр удамд өгснийг би та нарт хэлнэ.

43 Мөн ийн Их Эзэн Бурхан бибээр түүний ^асорилтын өдрүүдийг хүмүүнд тогтоов—

36а С ба Г 76:25–26;

Моце 4:1–4.

б Иса. 14:12–14;

С ба Г 76:28–29.

в су Хүндэтгэл.

г су Тэнгэр дэх

Зөвлөл.

д су Сонгох эрх.

е С ба Г 38:1; 45:1.

су Мөнх бус
байдлын өмнөх
амьдрал.

ё Илч. 12:3–4.

37а су Чөтгөр.

б 2 Петр 2:4;

Иудей 1:6;

Моце 7:26.

су Тэнгэр элчүүд.

38а су Там.

39а Моце 4:3–4.

су Уруу татах, Уруу
таталт.

б Моце 6:55.

40а Эхл. 3:6;

Моце 4:7–13.

б 2 Ниф. 10:24;

Мозая 16:3–5;

Алма 5:41–42.

41а су Еден.

б су Адам, Ева

хоёрын уналт.

в су Сүнсний үхэл.

г С ба Г 29:27–28;

76:31–39.

д Алма 40:26.

42а Моце 5:6–8.

б су Наманчлах,
Наманчлал.

в су Гэтэлгэх,

Гэтэлгэгдэх,

Гэтэлгэл.

г Алма 12:28–30.

д 2 Ниф. 2:21.

су Биений үхэл.

43а Алма 12:24; 42:10.

ингэснээр бүр итгэсэн болгоны адилаар тэрээр ердийн үхлээрээ “үхэшгүй байдалд” мөнх амьдралд “босч болох бөлгөө;

44 Мөн итгээгүй тэд мөнхийн “яланд буюу; учир нь тэд наманчилдаггүй учраас тэд сүнсний уналтаасаа гэтэлгэгдэж чадахгүй бөлгөө;

45 Учир нь тэд гэрлээс илүүгээр харанхуйд дурладаг буюу, мөн тэдний “үйлүүд нь хилэнцэт бөлгөө, мөн тэд дуулгавартай дагахыг хүсдэг түүнээсээ” шан харамжаа хүлээн авдаг бөлгөө.

46 Гэвч болгоогтун, би та нарт хэлнэ, бага насны “хүүхдүүд дэлхийн сууринаас миний Төрсөн Ганцаар дамжин” гэтэлгэгддэг;

47 Иймийн тул, тэд нүгэл

үйлдэж эс чадна, учир нь тэд миний өмнө “хариуцлага хүлээж эхлэх хүртэл бага насны хүүхдүүдийг” уруу татах хүч Сатанд өгөгдсөн нь үгүй;

48 Учир нь агуу зүйлүүд “эцгүүдийнх нь гараас шаардагдаж болохын тулд, энэ нь бүр миний хүсдэгчлэн, миний тааллын дагуу тэдэнд өгөгдсөн билээ.

49 Мөн, дахин, би та нарт хэлж байна, мэдлэг бүхий хэнд ч наманчлахыг би зарлиглаагүй гэж үү?

50 Мөн “ойлголтгүй байх түүний хувьд, энэ нь бичигдсэний дагуу үйлдэх нь надад үлдэх авай. Мөн эдүгээ энэ цагт би чамд илүүг тунхаглах нь үгүй. Амен.

ХЭСЭГ 30

1830 оны есдүгээр сард Нью-Йоркийн Фейеттед болсон гурван өдрийн чуулганы дараа, гэхдээ Сүмийн ахлагчид салж явахын өмнө Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Давид Витмер, Бага Петр Витмер мөн Жон Витмер нарт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:115–116). Анхандаа энэ нь гурван илчлэлт болон нийтлэгджээ; Сургаал ба Гэрээний 1835 оны хэвлэлд Бошиглогч үүнийг нэг хэсэг болгон нэгтгэжээ.

1–4, Хичээнгүйлэн үйлчлэхэд алдсаны учир Давид Витмер бу-

руушаагдав; 5–8, Бага Петр Витмер леменчүүдэд хийх номлолд

436 Мосе 1:39.
су Мөнх бус, Мөнх бус байдал.

в су Мөнх амьдрал.
г су Амилуулалт.

44а С ба Г 19:7–12.
су Ял.

45а Иохан 3:18–20;
С ба Г 93:31–32.
б Мозая 2:32–33;

Алма 3:26–27;
5:41–42; 30:60.

46а Моро. 8:8, 12;
С ба Г 93:38.

су Хүүхэд,
Хүүхдүүд.

б С ба Г 74:7.
су Гэтэлгэх,
Гэтэлгэгдэх,
Гэтэлгэл.

47а су Хариуцах,
Хариуцлага,
Хариуцлагатай.

б су Уруу татах,
Уруу таталт.

48а С ба Г 68:25.

50а С ба Г 137:7–10.
су Мэдлэг.

Оливер Каудерийг дагалдан явах ёстой; 9–11, Жон Витмер сайн мэдээг номлохоор дуудагдав.

БОЛГООГТУН, “Давид, чи хүнээс ^бэмээж мөн хүч чадлын төлөө надад ^анайдах ёстой байсан ч тэгсэнгүйг би чамд хэлж байна.

2 Харин чамайг Бий Болгогч миний зүйлүүд дээр мөн чиний дуудагдсан тэрхүү тохинуулал дээр гэхээсээ илүүгээр оюун чинь “дэлхийн зүйлүүд дээр байсаар ирлээ; мөн чи миний Сүнсэнд мөн өөрийнхөө дээгүүр тавигдсан тэдэнд анхаарал тавьсангүй, харин миний зарлиглаагүй тэднээр ятгагдсан байна.

3 Иймийн тул, чи өөрийнхөө төлөө асуухаар миний гарт үлдэх ёстой, мөн өөрийнхөө хүлээн авсан тэрхүү зүйлүүдийн талаар “тунгаан бодогтун.

4 Мөн бибээр чамд цаашдын зарлигуудыг өгөх хүртэл эцгийн чинь гэр чиний гэр орон байх ёстой. Мөн чи Сүм дэх, мөн дэлхийн өмнөх, мөн орчин тойрныхоо бүс нутгууд дахь “тохинуулалд өөрийгөө зориулах ёстой. Амен.

5 Болгоогтун, “Петр, чи Оливер ахынхаа хамт ^баянд гарах ёстой; учир нь миний сайн

мэдээг тунхаглахын тулд чи амаа нээх ёстой нь надад зүйтэй байгаа тэрхүү ^ацаг ирлээ; тиймийн тул, бүү эмээгтүн, харин ахынхаа чамд өгөх үгс хийгээд зөвлөгөөнд ^аанхаарал тавигтун гэдгийг би чамд хэлж байна.

6 Мөн түүний хийгээд өөрийнхөө чөлөөлөлтийн төлөө залбирал болон итгэлд зүрх сэтгэлээ ямагт надад өргөн, түүний бүхий л зовлонгуудад чи зовж бай; учир нь “леменчүүдийн дунд миний ^бсүмийг өсгөн бэхжүүлэх хүчийг би түүнд өгсөн билээ;

7 Мөн сүмийн ажил хэргүүдийн талаар түүний ах Бага Иосеф Смитээс өөр сүмд түүний “дээр түүний зөвлөх байх хэнийг ч бибээр томилоогүй болой.

8 Иймийн тул, эдгээр зүйлүүдэд анхаарал тавьж мөн миний зарлигуудыг сахихад хичээнгүй байгтун, мөн чи мөнх амьдралд адислагдах болно. Амен.

9 Болгоогтун, миний үйлчлэгч Жон, чи энэ цагаас эхлэн цаашид “бүрээн дуу хоолой мэтээр миний сайн мэдээг ^бтунхаглах ёстой гэдгийг би чамд хэлж байна.

10 Мөн Филип Бурроус ахындаа, мөн чамайг тэнд

30 1а су Давид Витмер.

б Үйлс 5:29.

в Шаст. дэд 16:7–9.

2а С ба Г 25:10.

3а су Тунгаан бодох.

4а су Тохинуулагч;

Үйлчлэл.

5а су Бага Петр

Витмер.

б С ба Г 32:1–3.

в С ба Г 11:15.

г су Зөвлөгөө;

Сүмийн

удирдагчдыг

дэмжих.

6а С ба Г 3:20; 49:24.

су Леменчүүд.

б су Есүс Христийн

Хожмын Үеийн

Гэгээнтнүүдийн

Сүм.

7а С ба Г 20:2–3.

9а С ба Г 33:2.

б С ба Г 15:6.

сонсож болох эргэн тойрны тэрхүү бүс нутгуудад, тийм ээ, тэндээс чамайг явахыг би чамд зарлиглах хүртэл чи хөдөлмөрлөх ёстой.

11 Мөн чиний бүх зүрх сэтгэлийн бүхий л хөдөлмөр

чинь энэ цаг үеэс хойш Сионы төлөө байх ёстой; тийм ээ, “хүн юу хийж чадахаас үл ^бэмээн чи ямагт миний ашиг сонирхолд амаа нээх ёстой, учир нь би чамтай “хамт байна. Амен.

ХЭСЭГ 31

1830 оны есдүгээр сард Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Томас Б.Марш өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:115–117). Уг үйл явдал Сүмийн чуулганы яг дараахан болжээ (хэсэг 30-ын толгой гарчгийг үз). Томас Б.Марш уг сарын эхээр баптисм хүртэж мөн энэхүү илчлэлт өгөгдөхөөс өмнө Сүмд ахлагчаар томилогдсон байлаа.

1–6, Томас Б.Марш сайн мэдээг номлохоор дуудагдаж мөн гэр бүлийнхнийх нь сайн сайхан байдал амлагдав; 7–13, Тэвчээртэй байж ямагт залбиран, мөн Тайтгаруулагчийг дагахыг түүнд зөвлөв.

ТОМАС, хүү минь, миний ажил дахь итгэлийнхээ учир адислагдсан болой чи.

2 Болгоогтун, гэр бүлийнхээ учир чи олон зовлон зүдгүүр амслаа; гэсэн хэдий ч, бибээр чамайг болон гэр бүлийг чинь, тийм ээ, хүүхдүүдийг чинь адислах болно; мөн тэд итгэж мөн үнэнийг мэдэх мөн миний сүмд чамтай хамт нэг байх тэрхүү өдөр ирэх бөлгөө.

3 Зүрх сэтгэлээ өргөж мөн баясагтун, учир нь номло-

лын чинь цаг ирлээ; мөн хэл чинь чөлөөтэй байх болно, мөн чи агуу баяр хөөрийн “баярт мэдээг энэ үеийнхэнд тунхаглах ёстой.

4 Миний үйлчлэгч Бага Иосеф Смитэд илчлэгдсэн тэр зүйлүүдийг чи “тунхаглах ёстой. Чи энэ цагаас хойш номлож, тийм ээ, шатаагдахад аль хэдийн бэлэн байгаа ^бцагаан талбайгаас хурааж эхлэх ёстой.

5 Тиймийн тул, хадуураараа бүх сэтгэлээрээ “хадагтун, мөн нүглүүд чинь чамд ^бөршөөгдсөн авай, мөн чи нуруун дээрээ “боодлуудыг үүрэх болно, учир нь ‘хөдөлмөрлөгч нь хөлс шангаа хүртэх нь зохистой бөлгөө. Иймийн тул, гэр бүл чинь амьдрах болно.

11а Иса. 51:7

б су Зориг, Зоригтой;
Айдас.

в Мат. 28:19–20.

31 1а су Томас Б.Марш.

3а Иса. 52:7;

Лук 2:10–11;

Мозая 3:3–5.

4а Мозая 18:19;

С ба Г 42:12; 52:36.

б С ба Г 4:4–6.

5а Илч. 14:15.

б су Уучлах.

в С ба Г 79:3.

г Лук 10:3–11;

С ба Г 75:24.

6 Болгоогтун, би чамд үнэнээр хэлнэ, тэднээс зөвхөн багахан хугацаагаар явагтун, мөн миний үгийг тунхагла, мөн тэдэнд зориулан байрыг би бэлтгэх болно.

7 Тийм ээ, би хүмүүсийн зүрх сэтгэлийг “нээх болно, мөн тэд чамайг хүлээж авах болно. Мөн бибээр чиний гараар сүм байгуулах болно;

8 Мөн чи тэднийг “хүчирхэг болгож мөн тэдний цуглуулагдах тэр цагт нь тэднийг бэлтгэх ёстой.

9 “Зовлон зүдгүүрүүдэд ^бтэвчээртэй байгтун, доромжлох тэдний эсрэг бүү доромжил. “Гэрийнхнээ номхон дөлгөөн байдалд авч яв, мөн гуйвшгүй байгтун.

10 Болгоогтун, чи дэлхийд бус, харин сүмд эмч байх ёстой хэмээн би чамд хэлж байна, учир нь тэд чамайг хүлээн авах нь үгүй.

11 Миний хүсэх тэр зүг уруу өөрийнхөө замаар явагтун, мөн чи юу хийх болон хаашаа явах нь “Тайтгаруулагчаар чамд өгөгдөх болно.

12 Чи “уруу таталтанд орж мөн шагналаа алдахгүйн тулд ямагт ^бзалбирагтун.

13 Эцсээ хүртэл “итгэлтэй байгтун, мөн харагтун, би чамтай ^бхамт байна. Эдгээр үгс нь хүнээс буюу хүмүүсээс бус, харин надаас, бүр Есүс Христ, чиний Гэтэлгэгчээс, Эцэгийн ^атааллаар бөлгөө. Амен.

ХЭСЭГ 32

1830 оны аравдугаар сард Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Парлей П.Пратт болон Зиб Петерсон нарт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:118–120). Урьдчилан бошиглогдсон адислалуудынх нь тухай Сүм Мормоны Номноос олж мэдсэн леменчүүдийн талаар агуу сонирхол хийгээд хүслүүд ахлагчдад төрсөн байлаа. Үүний улмаас, тэр үед Өрнөд дэх индиан омгуудад ахлагчид илгээгдэх ёстой юу гэдэг талаар Их Эзэн тааллаа мэдүүлэг хэмээн даруухан залбирал хийгдсэн байлаа. Уг илчлэлт оршвой.

1–3, Парлей П.Пратт, Зиб Петерсон хоёр леменчүүдэд номлох мөн Оливер Каудери, мөн Бага Петр Витмер нарыг дагалдан явахаар дуудагдав; 4–5,

Тэд судруудыг ойлгохын тулд залбирах ёстой.

МӨН Эдүгээ би өөрийн Мүйлчлэгч “Парлей П.

7а су Хөрвүүлэг, Хөрвөгч.
8а С ба Г 81:5; 108:7.
9а су Дайсан.
б су Тэвчээр.
в су Гэр бүл—Эцэг эхийн хариуцлага.

11а су Тайтгаруулагч; Ариун Сүнс.
12а су Уруу татах, Уруу таталт.
б 3 Ниф. 18:17–21.
су Залбирал.
13а су Тэвчих.

б Мат. 28:20.
в су Есүс Христ—
Эрх мэдэл.
32 1а су Парлей, Пратт Паркер.

Прагтын талаар, болгоогтун, би амьдардгийн адилаар тэрээр миний сайн мэдээг тунхаглаж мөн миний тухай ^бмэдэж авч, мөн номхон хийгээд зүрх сэтгэлдээ даруу байхыг би хүсч байна гэдгийг би түүнд хэлж байна.

2 Мөн түүнд миний томилсон зүйл нь, тэрээр миний үйлчлэгчид Оливер Каудери, Бага Петр Витмер хоёртой хамт аглаг буйдад “леменчүүдийн дунд ^бочих ёстой нь болой.

3 Мөн “Зиба Петерсон тэрчлэн тэдэнтэй хамт явах ёстой; мөн би өөрөө тэдэнтэй хамт

явж мөн тэдний ^бдунд байх болно; мөн бибээр Эцэгийн өмнө тэдний ^бөмгөөлөгч болой, мөн тэднийг дийлэх юу ч үгүй байх болно.

4 Мөн тэд бичигдсэн зүйлд “анхаарал тавьж, мөн өөр ^билчлэлтэд санаархах ёсгүй; мөн бибээр тэдний ^бойлголтод мөнхүү тэр зүйлийг ^бнээж болохын тулд тэд ямагт залбирах ёстой.

5 Мөн тэд эдгээр үгст анхаарал тавьж мөн хөнгөн хуумгай хандахгүй байх ёстой, мөн би тэднийг адислах болно. Амен.

ХЭСЭГ 33

1830 оны аравдугаар сард Нью-Йоркийн Фейеттед Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Эзра Тайре мөн Нортрон Свет нарт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:126–127). Энэхүү илчлэлтийг тэмдэглэхдээ, “Итгэлд хичээнгүйлэн эрэлхийлэгчдийг зааварлахад . . . Их Эзэн ямагт бэлэн байдгийг” Бошиглогч нотолжээ (History of the Church, 1:126).

1–4, Хөдөлмөрлөгчид сайн мэдээг арваннэг дэх цагт тунхаглахаар дуудагдав; 5–6, Сүм байгуулагдав, мөн сонгосон хүмүүс цугларах болно; 7–10, Наманчлагтун, учир нь тэнгэрийн хаант улс ойрхон байна; 11–15, Сүм сайн мэдээний хадан дээр баригдав; 16–18, Хүргэн Хүүгийн ирэлтэд бэлтгэгтүн.

БОЛГООГТУН, миний Бүйлчлэгчид Эзра, Норт-

роп та хоёрт би хэлнэ, чихээ нээж мөн “үг нь амьд хийгээд хүчирхэг, хоёр талдаа иртэй илднээс илүү хурц, үе мөч болон чөмгийг, сэтгэл хийгээд сүнсийг хэдэн хэсэг болгон салгах Бурхан Их Эзэнийхээ дуу хоолойг, мөн зүрхний ^ббодлууд мөн санааг ялган танигчийг анхаарагтун.

2 Учир нь үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ гажууд хийгээд тэрслүү үеийнхэнд

1б Мат. 11:28–30.
2а С ба Г 3:18–20.
б С ба Г 28:8; 30:5.
3а С ба Г 58:60.
б Мат. 18:20;
С ба Г 6:32; 38:7.

в су Өмгөөлөгч.
4а 1 Ниф. 15:25;
С ба Г 84:43–44.
б С ба Г 28:2.
в су Мэдлэг.
г ИС—Т 1:74.

33 1а Евр. 4:12;
Хил. 3:29–30.
б Алма 18:32;
С ба Г 6:16.

миний сайн мэдээг тунхаглахаар дуу хоолойгоо бүррэн “дуу мэт өргөхөөр та нар дуудагдсан авай.

3 Учрыг болгоогтун, “талбай нь цагаан хадахад бэлэн байна; мөн энэ нь ^барваннэг дэх цаг ажгуу, мөн бибээр ^сүүлчийн удаа хөдөлмөрлөгчдийг талбайдаа дуудах болно.

4 Мөн миний “талбай хэсэг бүртээ ^бялзарчээ; мөн цөөн хэдхэнээс өөр ^сайныг үйлдэгч хэн ч үгүй болой; мөн бүгдээр ялзарсан оюунтай болж, ^санваараар мэргэшсэний улмаас олон тохиолдолд тэд ^алдах болжээ.

5 Мөн үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, энэ “сүмийг бибээр ^ббайгуулж мөн аглаг буйдаас урагш дуудан гаргасан юм.

6 Мөн дэлхийн “дөрвөн зүгээс өөрийн сонгосон хүмүүсийг, мөн надад итгэх, мөн дуу хоолойг минь сонсох болгоныг бибээр ийн ^бцуглуулах болно.

7 Тийм ээ, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, талбай нь цагаан аль хэдийн хадахад бэлэн байна; иймийн тул, хадуураараа хадаж, мөн бүх

хүч, оюун, мөн чадлаараа хураагтун.

8 Амаа “нээгтүн мөн тэдгээр нь дүүргэгдэх болно, та нар бүр Иерусалимаас аглаг буйдад аялсан эртний ^бНифайн адил болох болно.

9 Тийм ээ, амаа нээгтүн мөн бүү татгалз, мөн та нар нуруун дээрээ “боодлуудыг үүрэх болно, учир нь харагтун, би та нартай хамт байна.

10 Тийм ээ, амаа нээгтүн мөн тэдгээр нь: Наманчлагтун, “наманчлагтун, мөн та нар Их Эзэний замыг бэлтгэгтүн, мөн түүний замуудыг шулуун болгогтун хэмээн хэлж дүүргэгдэх болно; учир нь тэнгэрийн хаант улс ойрхон байна;

11 Тийм ээ, та нар өөрсдийн нүглүүдийн ангижралын төлөө, хүн бүр наманчилж мөн “баптисм хүрт; тийм ээ, бүр усаар баптисм хүртэгтүн, мөн тэгээд галын мөн Ариун Сүнсний баптисм ирэх ажгуу.

12 Болгоогтун, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, энэ бол миний “сайн мэдээ бөлгөө; мөн тэд надад итгэх ёстой, эс бөгөөс тэд яавч аврагдаж чадахгүй гэдгийг санагтун;

2а Иса. 58:1.

3а Иохан 4:35;

С ба Г 4:4; 12:3; 14:3.

б Мат. 20:1–16.

в Иаков 5:71;

С ба Г 43:28.

4а су Их Эзэний талбай.

б 2 Ниф. 28:2–14;

Морм. 8:28–41.

в Ром. 3:12;

С ба Г 35:12.

г су Санваараар мэргэших.

д 2 Ниф. 28:14.

5а су Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм.

б су Сайн мэдээний сэргээлт.

6а 1 Ниф. 19:15–17.

б су Израил— Израилын

цугларалт.

8а С ба Г 88:81.

б 2 Ниф. 1:26–28.

9а Дуул. 126:6;

Алма 26:3–5;

С ба Г 75:5.

10а Мат. 3:1–3.

11а су Баптисм, Баптисм хүртээх.

12а 3 Ниф. 27:13–22.

13 Мөн энэ “хадан дээр би сүмээ барих болно; тийм ээ, энэ хадан дээр та нар баригдсан буюу, мөн та нар үргэлжлүүлэх аваас, тамын 6үүд та нарыг дийлэх нь үгүй.

14 Мөн сүмийн “тунхгууд хийгээд гэрээнүүдийг сахихаа та нар санах ёстой.

15 Мөн итгэл бүхий хэнийг ч гэсэн та нар “гар тавилтаар миний сүмд 6батлах болно, мөн бибээр Ариун Сүнсний 6бэлгийг тэдэнд хүртээх болно.

16 Мөн Мормоны Ном хийгээд ариун “судрууд нь та нарын 6зааврын тул надаас өгөгдсөн авай; мөн миний Сүнсний хүч бүх зүйлийг 6амьдруулдаг болгоо.

17 Иймийн тул, та нар “Хүргэн Хүүгийн ирэлтэнд бэлэн байж болохын тулд, ямагт залбиран, дэнлүүгээ бэлтгэж мөн асаан бас тосоо авч яван итгэлтэй байгтун—

18 Учрыг болгоогтун, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, бибээр гэнэт “ирнэ. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 34

1830 оны арваннэгдүгээр сарын 4-нд Нью-Йоркийн Фейеттед Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Оорсон Праттад өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:127–128). Пратт ах тэр үед арван есөн настай байв. Тэрээр сэргээгдсэн сайн мэдээний номлолыг анх удаа өөрийн ах Парлей П. Праттаас зургаан долоо хоногийн өмнө сонсоод, хөрвүүлэгдэж мөн баптисм хүртсэн байлаа. Энэхүү илчлэлт Ахмад Петр Витмерийн гэрт хүлээн авагджээ.

1–4, Итгэлтнүүд Цагаатгалаар дамжин Бурханы хөвгүүд болдог; 5–9, Сайн мэдээг номлох нь Хоёр дахь Ирэлтийн замыг бэлтгэдэг; 10–12, Бошиглол Ариун Сүнсний хүчээр ирдэг.

“ООРСОН Хүү минь, Их Эзэн Бурхан, бүр Есүс Христ, чиний Гэтэлгэгч би-

бээр чамд хэлэх тэр зүйлийг анхааран сонсож мөн дуулж мөн болгоогтун;

2 Дэлхийн “гэрэл ба амьдрал, харанхуйд гялалзагч гэрэл нь тэр бөгөөд харанхуй нь үүнийг ойлгох нь үгүй болгоо;

3 Итгэсэн болгон нь Бурханы “хөвгүүд болж болохын тулд

13а су Хад.
б Мат. 16:16–19;
с ба Г 10:69–70.

14а Хэсэг 20-22,
с ба Г 42:13-г
хамаарна.

15а су Гар тавих.
б С ба Г 20:41.

в су Ариун Сүнсний

бэлэг.

16а су Судрууд.

б 2 Тим. 3:16.

в Иохан 6:63.

17а Мат. 25:1–13.

су Хүргэн Хүү.

18а Илч. 22:20.

су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

34 1а су Оорсон Пратт.

2а Иохан 1:1–5.

су Гэрэл, Христийн
гэрэл.

3а Иохан 1:9–12;

Ром. 8:14, 16–17;

Моисе 6:64–68.

су Бурханы

хөвгүүд охид.

дэлхийг нэн ихээр ^бхайрлаж амьдралаа ^аөгсөн нь ^гтэр бөлгөө. Иймийн тул чи миний хүү болой;

4 Мөн чи итгэсний учир ^аадислагдсан болой чи;

5 Мөн чи миний сайн мэдээг номлохоор надаас ^ддуудагдсан учраас улам ч илүү адислагдсан болой чи —

6 Бүрээн дуу мэт дуу хоолойгоо удаан бөгөөд чангаар өргөхөөр, мөн Их Эзэний замыг түүний хоёр дахь ^аирэлтэд бэлтгэн, гажууд хийгээд тэрслүү үеийнхэнд наманчлалыг ^бтунхаглахаар буюу.

7 Учрыг болгоогтун, үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, миний бие ^гүүлэн дунд сүр хүч хийгээд агуу алдар сууд ирэх тэр ^дцаг ойрхон байна.

8 Мөн миний ирэлтийн үед энэ нь ^аагуу өдөр байх болно,

учир нь бүх үндэстнүүд ^бдагжин чичрэх болно.

9 Гэвч тэрхүү агуу өдөр тохиохын өмнө, нар харанхуйлж, сар цус болон хувирах болно; мөн одод гэрэлтэхээ больж, мөн зарим нь унах болно, мөн агуу устгалууд ёс бусыг үйлдэгчдэд тохиох ажгуу.

10 Иймийн тул, дуу хоолойгоо өргөж мөн бүү ^ататгалз, учир нь Их Эзэн Бурхан ярилаа; тиймийн тул бошигло, мөн энэ нь Ариун Сүнсний ^бхүчээр өгөгдөх болно.

11 Мөн хэрэв чи итгэлтэй байх аваас, болгоогтун, би ирэх хүртлээ чамтай хамт байна —

12 Мөн үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, би гэнэт ирнэ. Бибээр чиний Их Эзэн мөн чиний Гэтэлгэгч бөлгөө. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 35

1830 оны арванхоёрдугаар сард Нью-Йоркийн Фейеттед буюу үүний ойролцоо Бошиглогч Иосеф Смит мөн Сидней Ригдон нарт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:128–131). Энэ үед, Бошиглогч Библийн орчуулгыг бараг өдөр бүр хийж завгүй байв. Орчуулга 1830 оны зургадугаар сарын эхээр эхэлж, мөн Оливер Каудери, Жон Витмер хоёр хоёул бичээчээр үйлчилж байлаа. Эдүгээ тэд өөр ажил үүрэгт дуудагдсанаас хойш Сидней Ригдон энэ ажилд Бошиглогчийн бичээчээр үйлчлэхээр бурханлиг томилолтоор дуудагдсан байв (шүлэг 20-ийг үз). Энэхүү илчлэлтийн цэдгийнхээ

3б Иохан 3:16; 15:13.
 су Хайр.
 в су Цагаатгах,
 Цагаатгал;
 Гэтэлгэх,
 Гэтэлгэгдэх,
 Гэтэлгэл.
 г су Гэтэлгэгч.
 4а Иохан 20:29.

5а су Дуудах,
 Бурханаас
 дуудагдах,
 Дуудлага.
 6а су Есүс Христийн
 Хоёр дахь Ирэлт.
 б С ба Г 6:9.
 7а Лук 21:27.
 б Илч. 1:3.

8а Иоел 2:11;
 Малах. 4:5;
 С ба Г 43:17–26.
 су Есүс Христийн
 Хоёр дахь Ирэлт.
 б Иса. 64:2.
 10а Иса. 58:1.
 б 2 Петр 1:21.

өмнөх үг болгон Бошиглогч бичихдээ: “Арванхоёрдугаар сард Сидней Ригдон [Огайгоос] мөн түүнтэй хамт Эдвард Партриж Их Эзэнээс асуухаар ирэв... Энэ хоёр ахыг ирсний дараа удалгүй тийн Их Эзэн яриу” гэжээ (History of the Church, 1:128).

1-2, Хүмүүс хэрхэн Бурханы хөвгүүд болж болох нь; 3-7, Сидней Ригдон баптисм хүртээж мөн Ариун Сүнс хүртээхээр дуудагдав; 8-12, Тэмдгүүд хийгээд гайхамшгууд итгэлээр гүйцэтгэгддэг авай; 13-16, Их Эзэний үйлчлэгчид Сүнсний хүчээр үндэстнүүдийг шигших болно; 17-19, Иосеф Смит нууцуудын түлхүүрүүдийг атгадаг; 20-21, Сонгогдсон хүмүүс Их Эзэний ирэлтийн өдрийг тэсвэрлэх болно; 22-27, Израил аврагдах болно.

АНХААРАГТУН, “Их Эзэн Бурханыхаа, бүр ^аАльфа ба ^бОмега, эхлэл ба төгсгөл, “замнал нь нэгэн мөнхийн эргэлт, ^вөнөөдөр, өчигдөр мөн үүрд адил болох түүний дуу хоолойг буюу.

2 Би бол Есүс Христ, Бурханы Хүү, бүр миний нэрэнд “итгэсэн болгон нь Бурханы ^бхөвгүүд, бүр би Эцэгт ^внэг, Эцэг надад нэгийн адилаар надад ^внэг байж болохын тулд, бид нэг байж болохын тулд дэлхийн нүглүүдийн

тул ^вцовдлогдсон тэрбээр бөлгөө.

3 Болгоогтун, үнэнээр, үнэнээр, би өөрийн үйлчлэгч Сидней чамд хэлж байна, би чамайг хийгээд чиний ажлуудыг харлаа. Би залбирлуудыг чинь сонслоо, мөн чамайг илүү агуу ажилд бэлтгэсэн юм.

4 Адислагдсан болой чи, учир нь чи агуу зүйлүүдийг хийх болно. Болгоогтун чи миний өмнө, мөн ирэх ёстой тэрхүү “Елиагийн өмнө замыг бэлтгэх бүр ^бИоханы адилаар урагш илгээгдсэн бөлгөө, харин чи үүнийгээ мэдсэн нь үгүй.

5 Чи наманчлалын тул усаар баптисм хүртээлээ, гэвч тэд Ариун Сүнс “хүлээж аваагүй байна;

6 Харин эдүгээ чи усаар “баптисм хүртээх болно, бүр эртний төлөөлөгчдийн адилаар ^бгар тавьснаар, тэд ^вАриун Сүнснийг хүлээн авах болно хэмээх зарлигийг би чамд өгч байна.

7 Мөнхүү улиран тохиох дор уг нутагт, бүр “харийнханы

35 1а су Их Эзэн.

б Илч. 1:8.

су Альфа ба Омега.

в 1 Ниф. 10:19;

С ба Г 3:2.

г Евр. 13:8;

С ба Г 38:1-4; 39:1-3.

2а С ба Г 20:25; 45:5, 8.

б су Бурханы

хөвгүүд охид.

в су Бурхан, Бурхан тэргүүтэн.

г Иохан 17:20-23.

су Нэгдэл.

д су Цовдлуулалт.

4а 3 Ниф. 25:5-6;

С ба Г 2:1; 110:13-15.

б Малах. 3:1; Мат. 11:10;

1 Ниф. 11:27;

С ба Г 84:27-28.

5а Үйлс 19:1-6.

6а су Баптисм,

Баптисм хүртээх.

б су Гар тавих.

в су Ариун Сүнсний

бэлэг.

7а су Харийнхан.

дунд агуу ажил байх болно, учир нь тэдний мунхаглал хийгээд тэдний жигшүүрт хэргүүд бүх хүмүүсийн нүдэнд үзүүлэгдэх болно.

8 Учир нь бибээр Бурхан болой, мөн миний мутар “богиносоогүй байна; мөн миний нэрэнд ^битгэх тэд бүгдэд ^агайхамшгууд, ^гтэмдгүүд хийгээд гайхалтай зүйлүүдийг үзүүлэх болно би.

9 Мөн миний нэрэнд, “итгэлд үүнийг асуух хэн боловч тэд ^бчөтгөрүүдийг “хөөн зайлуулах болно; тэд өвчтөнүүдийг ^вэдгээх болно; тэд хараагүйчүүдийг харах, мөн дүлийчүүдийг сонсох, мөн хэлгүйчүүдийг ярих, мөн хазгаруудыг алхах болгоно.

10 Мөн агуу их зүйлүүд хүмүүний үрст урагш үзүүлэгдэх тэр цаг удахгүй ирнэ;

11 Гэвч бүх үндэстнүүдийг өөрийн “завхайрлын хилэнгийн дарснаас уухад хүргэсэн мөнөөх ^бВавилоны “эзгүйрлээс өөр юу ч, ^витгэлгүйгээр үзүүлэгдэхгүй байх болно.

12 Мөн энэ үеийнхэнд миний урагш илгээсэн миний бүрэн сайн мэдээг хүлээн

авахад бэлэн байгаа тэднээс өөр “хэн ч сайныг үйлддэггүй бөлгөө.

13 Иймийн тул, Сүнснийхээ хүчээр үндэстнүүдийг шигшихийн тулд бибээр дэлхийн “сул дорой зүйлүүдийг, ^бэрдэмд боловсроогүй тэднийг хийгээд гадуурхагдагсдыг дуудаж байна;

14 Мөн тэдний гар миний мутар байх болно, мөн бибээр тэдний “халхавч мөн бамбай нь байх болно; мөн бибээр тэдний бүсийг бүслэх болно, мөн тэд миний төлөө эрэлхгээр тулалдах болно; мөн ^бдайснууд нь тэдний хөл дор байх болно; мөн бибээр илдийг тэдний тусын тулд ^вунахаар болгоно, мөн зэвүүцлийнхээ ^вгалаар тэднийг хамгаалах болно би.

15 Мөн сайн мэдээ нь “ядуус хийгээд ^бномхон дөлгөөнчүүдэд номлогдох болно, мөн тэд миний ирэлтийн цагийг ^вширтэн хүлээж байх болно, учир нь энэ нь ^войрхон байна—

16 Мөн тэд “инжир модны тухай сургаалт зүйрлэлийг сурах болно, учир нь бүр эдүгээ зун аль хэдийн ойрхон байна.

8а Иса. 50:2; 59:1.
 б су Итгэлтэй байх, Итгэл.
 в су Гайхамшиг.
 г су Тэмдэг.
 9а су Итгэл.
 б Марк 1:21–45.
 в Марк 16:17.
 г су Эдгээх, Эдгэрэх.
 11а Илч. 18:2–4.
 б су Бабел, Вавилон.
 в С ба Г 5:19–20.

г С ба Г 63:11–12.
 12а Ром 3:10–12;
 С ба Г 33:4;
 38:10–11; 84:49.
 13а 1 Кор. 1:27;
 С ба Г 1:19–23; 124:1.
 б Үйлс 4:13.
 14а 2 Сам. 22:2–3.
 б С ба Г 98:34–38.
 в С ба Г 1:13–14.
 г С ба Г 128:24.
 15а Мат. 11:5.

б су Номхон дөлгөөн, Номхон дөлгөөн байдал.
 в 2 Петр 3:10–13;
 С ба Г 39:23; 45:39;
 Моце 7:62.
 г С ба Г 63:53.
 16а Мат. 24:32;
 С ба Г 45:36–38;
 ИС—А 1:38.
 су Цаг хугацааны тэмдгүүд.

17 Мөн бибээр сайн мэдээний “бүрэн байдлаа өөрийн үйлчлэгч ⁶Иосефын гараар урагш илгээсэн буюу; мөн суул дорой байхад нь бибээр түүнийг адисалсан билээ;

18 Мөн хэрэв тэрээр надад итгэлтэй хэвээр үлдэх аваас “лацдагдсан тэдгээр зүйлүүд, бүр дэлхийн ⁶сууринаас байсан зүйлүүд, мөн энэ үес миний ирэлтийн үе хүртэл тохиох тэдгээр зүйлүүдийн нууцын ⁴түлхүүрүүдийг түүнд өгсөн бөлгөө, мөн хэрэв үгүй аваас, түүний оронд бибээр өөр нэгнийг тавих болно.

19 Иймийн тул, түүний итгэл алдрахгүйн тулд түүнийг харж хандагтун, мөн энэ нь бүх зүйлийг мэддэг ⁴Ариун Сүнс, ⁶Тайтгаруулагчаар өгөгдөх болно.

20 Мөн түүнд зориулан чи “бичих ёстой хэмээх нь чамд миний өгөх зарлиг болой; мөн судрууд нь, бүр тэдгээр нь миний цээжинд байдагчлан, миний өөрийн ⁶сонгосон тэдний авралд өгөгдөх болно;

21 Учир нь тэд миний “дуу хоолойг сонсох болно, мөн

намайг үзэх болно, мөн унтаж байх нь үгүй бөлгөө, мөн миний ⁶ирэлтийн өдрийг “тэсвэрлэх болно; учир нь бүр би ‘цэвэр ариуны адилаар, тэд цэвэршигдэх болно.

22 Мөн эдүгээ би “чамд хэлж байна, түүнтэй үлдэгтүн, мөн тэрээр чамтай хамт аялах болно; түүнийг бүү орхи, мөн эдгээр зүйлүүд гарцаагүй биелэгдэх болно.

23 Мөн та нарыг “бичээгүй байх үед чинь, болгоогтун, бошиглох нь түүнд өгөгдөх болно; мөн чи миний сайн мэдээг номлож мөн тэдгээр нь түүнд өгөгдөхийн хэрээр түүний үгсийг нотлохын тулд ⁶ариун бошиглогчдод хандах ёстой.

24 Та нар үүрэг хүлээсэн бүх зарлигууд хийгээд гэрээнүүдээ “сахигтун; мөн та нарын сайн сайхны төлөө бибээр тэнгэрийг ⁶сэгсрэх болгоно, мөн “Сатан дагжин чичирч мөн Сион толгод дээр ‘баясан мөн цэцэглэн хөгжих болно;

25 Мөн миний өөрийн тогтоосон цагт “Израил ⁶аврагдах болно; мөн миний өгсөн “түлхүүрүүдээр тэд хөтлөгдөх

17a С ба Г 42:12.

б С ба Г 135:3.

18a Дан. 12:9;

Мат. 13:35;

2 Ниф. 27:10–11;

Ифер 4:4–7;

ИС—Т 1:65.

б С ба Г 128:18.

в С ба Г 84:19.

19a су Ариун Сүнс.

б Иохан 14:16, 26; 15:26.

су Тайтгаруулагч.

20a Бошиглогч энэ үед

Сидней Ригдон

бичээчээр дуудагд-

сан Библийн илчлэгдсэн орчуулган дээр ажиллаад завгүй байв.

б су Сонгох.

21a Иоел 2:11;

С ба Г 43:17–25;

88:90; 133:50–51.

б су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

в Малах. 3:2–3.

г су Цэвэр ариун,

Цэвэр ариун

байдал.

22a С ба Г 100:9–11.

23a ө.х. Сидней Ригдоны бичиглэлд оролцоогүй байсан үе.

б ө.х. Судрууд.

24a С ба Г 103:7.

б С ба Г 21:6.

г 1 Ниф. 22:26.

д су Баяр баясгалан.

25a су Израил.

б Иса. 45:17;

1 Ниф. 19:15–16;

22:12.

в су Санваарын

түлхүүрүүд.

болно, мөн дахиад будлиу-
лагдах нь огт үгүй болой.

26 Зүрх сэтгэлээ өргөж, мөн
баяртай байгтун, та нарын
“гэтэлгэл ойртож байна.

27 Бүү эмээ бяцхан сүрэг
минь, “хаант улс намайг ирэх
хүртэл та нарынх бөлгөө.
Болгоогтун, би гэнэт ^бирнэ.
Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 36

1830 оны арванхоёрдугаар сард Нью-Йоркийн Фейеттийн ойролцоо Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Эдвард Партрижид өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:131). (Хэсэг 35-ын толгой гарчгийг үз.) “Эдвард Партриж бол сүсгийн загвар болсон, мөн Их Эзэний агуу хүмүүсийн нэг байлаа” хэмээн Бошиглогч хэлжээ (History of the Church, 1:128).

1–3, Их Эзэн Сидней Ригдоны гараар Эдвард Партрижийн дээр мутраа тавьжээ; 4–8, Сайн мэдээг мөн санваарыг хүлээж авдаг хүн болгон урагш одож мөн номлохоор дуудагдах ёстой.

ИЗРАИЛЫН “Хүчирхэг Нэгэн, Их Эзэн, Бурхан ийн хэлжээ: Болгоогтун, миний үйлчлэгч ^бЭдвард би чамд хэлнэ, адислагдсан болой чи, мөн нүглүүд чинь чамд өршөөгдсөн болой, мөн чи миний сайн мэдээг бүрэн дуу хоолой мэт номлохоор дуудагдсан билээ;

2 Мөн бибээр өөрийн үйлчлэгч Сидней Ригдоны гараар чиний дээр “мутраа тавих болно, мөн чи миний Сүнсийг, Ариун Сүнсийг бүр хаант улсын ^бамар амгалангийн зүйлүүдийг чамд заах

тэрхүү “Тайтгаруулагчийг чи хүлээж авах болно;

3 Мөн чи үүнийг: Хосанна, хамгаас эрхэм Бурханы нэр адислагдах болтугай хэмээн хэлж, чанга дуу хоолойгоор тунхаглах ёстой.

4 Мөн эдүгээ би бүх хүмүүнд холбогдуулан энэхүү дуудлага хийгээд зарлигийг чамд өгч байна—

5 Энэхүү дуудлага хийгээд зарлигийг хүлээн авч, миний үйлчлэгч Сидней Ригдон, Бага Иосеф Смит нарын өмнө очих болгон нь “томилогдож мөн үүрдийн сайн мэдээг үндэстнүүдийн дунд ^бномлохоор урагш илгээгдэх ёстой—

6 Наманчлалыг тунхаглан, өгүүлрүүн: Зөрүүд энэ үеийнхнээс өөрсдийгөө “хамгаалагтун мөн махан биеэр бузарлагдсан ^бөмсгөлийг хүр-

26a Лук 21:28.

27a су Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс.
б Илч. 22:20.

36 1a су Есүс Христ;

Иехова.
б С ба Г 41:9–11.

2a су Гар тавих.

б С ба Г 42:61.

в су Тайтгаруулагч;
Ариун Сүнс.

5a С ба Г 63:57.

су Томилох,
Томилолт.

б су Номлох.

6a Үйлс 2:40.

б Иудей 1:23.

тэл жигшин галаас урагш гарч ирэгтүн.

7 Мөн үүнийг бүхий л зүрх сэтгэлээрээ хүлээн авагч хүн болгон, бүр миний хэлсэнчлэн томилогдож урагш илгээгдэж болохын тулд

энэхүү зарлиг миний сүмийн ахлагчдад өгөгдөх ёстой.

8 Би бол Есүс Христ Бурханы Хүү болой; иймийн тул, хормойгоо шуугтун, мөн би “ариун сүмдээ гэнэт ирэх болно. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 37

1830 оны арванхоёрдугаар сард Нью-Йоркийн Фейеттийн ойролцоо Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон хоёрт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:139). Энэ эрин үед тохиох цугларалтын талаар анхны зарлиг үүнд өгөгджээ.

1–4, Гэгээнтнүүд Огайод цугла-
рахаар дуудагдав.

БОЛГООГТУН, та нар Огайо уруу явах хүртлээ та нар дахиад “орчуулах нь надад зүйтэй бус гэдгийг би та нарт хэлж байна, мөн энэ нь дайсны улмаас мөн та нарын ашиг тусын тулд болой.

2 Мөн дахин, та нар тэдгээр хэсгүүдэд миний сайн мэдээг номлох мөн сүм байгаа газруудад хаана ч байлаа гэсэн, ялангуяа “Колесвиллд бүр ч илүү, сүмийг бэхжүүлэх хүрт-

лээ та нар явах ёсгүй гэдгийг би та нарт хэлнэ; учир нь, болгоогтун, тэд маш их итгэлээр надад хандан залбирдаг билээ.

3 Мөн дахин, сүмд миний өгөх зарлиг бол миний үйлчлэгч Оливер Каудери тэдэнд эргэж ирэх тэрхүү цагт бэлтгэн, тэд “Огайод хамтдаа чуулан цуглах ёстой нь надад зүйтэй байна.

4 Болгоогтун, энэ нь мэргэн ухаан болой, мөн намайг ирэх хүртэл хүн болгон өөрийнхөө тулд “сонгож аваг. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 38

1831 оны нэгдүгээр сарын 2-нд Нью-Йоркийн Фейеттед Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:140–143). Уг үйл явдал нь Сүмийн чуулган байлаа.

1–6, Христ бүх зүйлийг бүтээв;
7–8, Тэрбээр удахгүй өөрийг нь харах Гэгээнтнүүдийнхээ дунд

байна; 9–12, Бүх махбодь түүний өмнө ялзарчээ; 13–22, Тэрээр амлалтын нутгийг өөрийн

8а Малах. 3:1.
37 1а ө.х. Библийн
орчуулга аль

хэдийн эхэлсэн
байв.
2а С ба Г 24:3; 26:1.

3а ө.х. Огайо муж улс.
С ба Г 38:31-32.
4а су Сонгох эрх.

Гэгээнтнүүдэд зориулан энэ амьдралд хийгээд үүрд мөнхөд хадгалан үлдээжээ; 23-27, Нэг байж мөн бие биенээ ах дүүс мэтээр хүндэтгэхийг Гэгээнтнүүдэд зарлиг болгов; 28-29, Дайнууд угтан хэлэгдэв; 30-33, Гэгээнтнүүдэд тэнгэрээс хүч өгөгдөх болно мөн бүх үндэстнүүдийн дунд урагш одох ёстой; 34-42, Ядуус хийгээд гачигдагсдын төлөө халамж тавьж мөн үүрд мөнхийн баялгуудыг эрэлхийлэхийг Сүмд зарлиг болгов.

ЧИНИЙ Их Эзэн Бурхан, Бүр Есүс Христ, Агуу “Би байдаг, Альфа ба Омега, ^бэхлэл ба төгсгөл, үүрд мөнхийн өргөн уудмыг, мөн тэнгэрийн бүх серафим ^түмнийг дэлхий ^ббүтээгдэхээс ^өөмнө хардаг байсан мөнхүү тэр нь буюу;

2 Бүх зүйлүүдийг ^амэддэг, учир нь ^ббүх зүйлүүд мэлмийнх нь өмнө байдаг тэрбээр ийн хэлдэг билээ.

3 Мөн ярьсан тэр нь би бөлгөө, мөн дэлхий ^ахийгдсэн, мөн бүх зүйл надаар дамжин ирсэн билээ.

4 Енохын ^аСионыг цээжиндээ тэврэн аваачсан тэр

нь би бөлгөө; мөн үнэнээр, би хэлнэ, бүр миний нэрэнд ^битгэсэн болгоныг буюу, учир нь би бол Христ, мөн өөрийн нэрээр, урсгасан ^ццусаараа дамжуулан, тэдний төлөө би Эцэгийн өмнө гуйсан бөлгөө.

5 Гэвч болгоогтун, дэлхийн төгсгөлд тохиох тэрхүү агуу өдрийн ^шшүүлт хүртэл ^өөс бусчуудын үлдсэнийг нь би харанхуйн ^ггинжинд хадгалсаар байгаа болой;

6 Мөн миний дуу хоолойг үл сонсох атлаа зүрх сэтгэлээ хатууруулах тэднийг, бүр өс бусыг үйлдэгчдийг бибээр тэрхүү байдалд нь энэчлэн хадгалсаар байх болгоно, мөн ай халаг, ай халаг, ай халаг, тэдний муу заяа.

7 Гэвч болгоогтун, миний ^амэлмий та нарын дээр байна гэдгийг үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ. Би та нарын ^ддунд байна мөн та нар намайг харж чадах нь үгүй болой;

8 Гэвч та нар намайг ^ахарах, мөн би байдгийг мэдэх тэр өдөр удахгүй ирнэ; учир нь харанхуйн хөшиг удахгүй урагдах болно, мөн ^ццэвэр-

38 1а су БИ БАЙДАГ.

б Илч. 1:8.

в С ба Г 45:1.

г Дуул. 90:2.

д су Мөнх бус байдлын өмнөх амьдрал.

2а С ба Г 88:41;

Моисе 1:35.

су Бүхнийг Мэдэгч.

б Сур. үгс 5:21;

2 Ниф. 9:20.

3а Дуул. 33:6-9.

су Бүтээх, Бүтээл.

4а С ба Г 45:11-14;

76:66-67; 84:99-100;

Моисе 7:18-21. исо,

Эхл. 14:25-40.

су Сион.

б С ба Г 20:25;

35:2; 45:3-5.

в су Цагаатгах,

Цагаатгал.

5а су Эцсийн шүүлт.

б су Зөв шударга

бус, Зөв шударга

бус явдал.

в 2 Петр 2:4;

Иудей 1:6.

су Там.

7а С ба Г 1:1.

б С ба Г 6:32; 29:5.

8а Илч. 22:4-5.

су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

б су Цэвэр ариун,

Цэвэр ариун

байдал.

шээгүй тэр нь уг өдрийг “тэсвэрлэх нь үгүй бөлгөө.

9 Иймийн тул, хормойгоо шууж мөн бэлтгэгдсэн байгтун. Болгоогтун, “хаант улс та нарынх болой, мөн дайсан дийлэх нь үгүй болно.

10 Үнэнээр би та нарт хэлнэ, “цэвэр ариун болой та нар, гэвч бүгдээрээ биш; мөн миний ^бтаалалд нийцэх өөр хэн ч үгүй бөлгөө;

11 Учир нь бүх “махбодь миний өмнө ялзарчээ; мөн ^бхаранхуйн хүчнүүд дэлхий дээр хүмүүний үрсийн дунд, тэнгэрийн бүх түмний дэргэд ноёрхож байна —

12 Энэ нь чимээгүй байдал ноёрхоход хүргэсэн ажгуу, мөн бүх үүрд мөнх нь “өвчилж мөн ^бтэнгэр элчүүд дэлхийг ^хадаж, ^штатааж болох ^дхогийн ургамлыг цуглуулах агуу зарлигийг тэд хүлээж байна; мөн, болгоогтун, дайсан нэгдээд байна.

13 Мөн эдүгээ би та нарт нэг нууцыг, улирах цагийн явцад бүр та нарын “устгалыг тохиолгон авчрах нууц өрөөнд байгаа нэг зүйлийг үзүүлбэ, мөн та нар үүнийг мэдсэн нь үгүй бөлгөө;

14 Гэвч эдүгээ би та нарт үүнийг ярья, мөн адислагд-

сан болой та нар, та нарын алдсын, бас та нарын итгэлгүй зүрх сэтгэлийн учраас бус болой; учир нь үнэхээр та нарын зарим нь миний өмнө гэмтэй бөлгөө, гэвч та нарын сул дорой байдалд би нигүүлсэнгүй байх болно.

15 Тиймийн тул, та нар энэ үеэс хойш “хүчтэй байгтун; бүү ^бэмээ, учир нь хаант улс та нарынх болой.

16 Мөн та нарын авралын тулд би та нарт нэг зарлиг өгч байна, учир нь би та нарын залбирлуудыг сонссон бөлгөө, мөн “ядуус миний өмнө гомдоллов, мөн ^ббаячуудыг би бий болгосон, мөн бүх махбодь минийх бөлгөө, мөн бибээр хүмүүсийн ^нүүр тал харагч биш билээ.

17 Мөн бибээр дэлхийг баян болгосон билээ, мөн болгоогтун энэ бол миний “хөлийн гишгүүр болой, иймийн тул, би дахин үүн дээр зогсох болно.

18 Мөн Их Эзэнийг ирэхэд үүн дээр зүхэл байх нь үгүй сүү хийгээд зөгийн балаар бялхагч нутгийг, бүр амлалтын нутгийг бас агуу баялгуудыг та нарт соёрхон өгөхөөр бибээр урагш өргөн барьж байна;

8в Малах. 3:2.

9а Лук 6:20.

су Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс.

10а су Цэвэр болон Цэвэр бус байдал.

б С ба Г 1:30.

11а Иса. 1:3–4;

С ба Г 33:4.

б Мика 3:6;

С ба Г 112:23;

Моисе 7:61–62.

12а Моисе 7:41.

б С ба Г 86:3–7.

в су Ургац хураалт.

г Мат. 13:30.

д С ба Г 88:94;

101:65–66.

13а С ба Г 5:32–33.

15а су Зориг, Зоригтой.

б су Айх—Хүнээс айх.

16а Моиза 4:16–18.

б 1 Сам. 2:7.

в Үйлс 10:34;

Моро. 8:11–12;

С ба Г 1:34–35.

17а 1 Ниф. 17:39;

Абр. 2:7.

19 Мөн хэрэв та нар үүнийг бүхий л зүрх сэтгэлээрээ эрэлхийлэх аваас, бибээр үүнийг та нарын өвийн нутаг болгон та нарт өгөх болно.

20 Мөн энэ нь та нартай хийх миний гэрээ байх болно, өвийн чинь нутгийн тул, мөн дэлхий оршин байх цагт та нарын үр хүүхдүүдийн үүрдийн “өвийн тул энэ нь та нарт байх болно, мөн та нар үүнийг үүрд мөнхөд дахин эзэмших болно, дахин алга болох нь үгүй бөлгөө.

21 Гэвч, цаг нь болоход та нар хаан, эсвээс захирагчгүй байх болно гэдгийг үнэнээр би та нарт хэлж байна, учир нь бибээр та нарын “хаан байж мөн та нарыг харж хандаж байх болно.

22 Иймийн тул, дуу хоолойг минь сонсож мөн намайг “дагагтун, мөн та нар ^бчөлөөт хүмүүс байх болно, мөн намайг ирэхэд байх миний хуулиудаас өөр хуулиуд та нарт байхгүй байх болно, учир нь бибээр та нарын ^вхууль тогтоогч болой, мөн миний мутрыг юу зогсоож чадах билээ?

23 Гэвч, үнэнээр би та нарт хэлнэ, би та нарыг томилсон тэрхүү албан тушаалын дагуу бие биендээ “заагтун;

24 Мөн хүн бүр ах дүүсээ өөр

шигээ “хүндлэг, мөн ^бариун журам хийгээд ^вцэвэр ариун байдлыг миний өмнө байнга үйлдэгтүн.

25 Мөн дахин би та нарт хэлж байна, хүн бүр ах дүүсээ өөр шигээ хүндлэг.

26 Учир нь та нарын дунд хэн чинь арванхоёр хүүтэй байгаад, тэднийгээ ялгаварлан үздэггүй, мөн тэд түүнд дуулгавартай үйлчилдэг байхад, мөн тэрээр нэгэнд нь: Чи сайхан хувцас өмсөн мөн чи энд суу хэмээн хэлэхүл; мөн нөгөөд нь: Чи ноорхой хувцас өмсөн мөн чи тэнд суу гээд — мөн хөвгүүдээ харж тэгээд би шударга байна гэж хэлэх вэ?

27 Болгоогтун, үүнийг би та нарт сургаалт зүйрлэл өглөө, мөн энэ нь бүр миний нэгэн адил билээ. Би та нарт хэлнэ, “нэг байгтун; мөн хэрэв та нар нэг байхгүй аваас, та нар минийх биш болой.

28 Мөн дахин, дайсан нууц хуйвалдаануудад та нарын “амийг эрэлхийлж байгааг би та нарт хэлж байна.

29 Та нар алс холын орнууд дахь “дайнуудын тухай сонсдог, мөн алс холын орнуудад мөд агуу дайнууд байх болно хэмээн та нар ярьдаг, гэвч та нар өөрийнхөө нутаг дахь

20a С ба Г 45:58.

21a Зех. 14:9;

2 Ниф. 10:14;

Алма 5:50.

22a Иохан 10:27.

б су Есус Христ—

Христийн Мянган

жилийн хаанчлал.

в Иса. 33:22; Мика 4:2;

С ба Г 45:59.

23a С ба Г 88:77–79,

118, 122.

су Заах, Багш.

24a Дэд хууль 17:20;

1 Кор. 4:6.

б С ба Г 46:33.

су Нөлөөлөх хүч.

в су Ариун байдал.

27a Иохан 17:21–23;

1 Кор. 1:10;

Ефес 4:11–14;

3 Ниф. 11:28–30;

Моисе 7:18.

су Эв нэгдэл.

28a С ба Г 5:33; 38:13.

29a С ба Г 45:26, 63;

87:1–5; 130:12.

хүмүүсийн зүрх сэтгэлийг мэдэх нь үгүй.

30 Та нарын залбирлуудын улмаас би эдгээр зүйлүүдийг та нарт ярилаа; иймийн тул, хүмүүний ёс бус явдал нь тэдний ёс бус явдлаар эдгээр зүйлүүдийг, дэлхийг сэгсрэхээс илүү чанга дуугаар та нарын чихэнд ярих байдлаар та нарт илчлэхгүйн тулд цээжиндээ “мэргэн ухааныг” нөөцөл; харин хэрэв та нар бэлтгэгдэх аваас, та нар эмээх нь үгүй.

31 Мөн та нар дайсны хүчнээс зугтааж, мөн “толбогүй хийгээд буруугүй зөв шударга хүмүүс болж надад цугларч болохын тулд буюу—

32 Иймийн тул, энэ шалтгааны учир та нар “Огайу уруу явах ёстой хэмээх зарлигийг би та нарт өгч байна; мөн тэнд би та нарт өөрийн “хуулийг өгөх болно; мөн тэнд та нар тэнгэрийн хүчээр “хишиг хүртэх болно;

33 Мөн тэндээс, миний хүсэн хэн ч бай “бүх үндэстнүүдийн дотор урагш одох ёстой бөгөөд тэд юу хийх ёстой нь тэдэнд хэлэгдэх болно; учир нь агуулахад нөөцлөгдсөн агуу ажил надад байна, учир нь Израил “аврагдах болно, мөн бибээр тэднийг хүссэн тийшээгээ хөтлөн дагуулах болно, мөн миний мутрыг

“зогсоох хүч гэж үгүй байх болно.

34 Мөн эдүгээ, тэдний дундаас тодорхой эрчүүд томилогдох ёстой, мөн тэд сүмийн “дуу хоолойгоор томилогдох ёстой хэмээх зарлигийг бибээр эдгээр газрууд дахь сүмд өгч байна;

35 Мөн тэд ядуус хийгээд гачигдагсдыг харж хандаж, мөн тэд зовохгүй байхын тулд тэднийг “хөнгөвчлөхөөр тусламж үзүүлэх ёстой; мөн тэдэнд миний зарлигласан газарт тэднийг урагш илгээх болно;

36 Мөн энэ сүмийн өмч хөрөнгийн хэрэг явдлуудыг эрхлэх нь тэдний ажил байх болно.

37 Мөн зарж чадахгүй байгаа фермүүдтэй тэд, аль нь сайн болохыг харгалзан тэдгээрийг үлдээх буюу түрээслэг.

38 Бүх зүйлүүд хамгаалагдсан байхыг анхаарагтун; мөн хүмүүс тэнгэрийн хүчээр “хишиг хүртээгдэж мөн урагш илгээгдэхэд эдгээр бүх зүйл сүмийн цээжинд цуглуулагдах болно.

39 Мөн хэрэв та нарт өгөх нь Эцэгийн таалал болох тэрхүү “баялгуудыг та нар эрэлхийлэх аваас, та нар бүх хүмүүсээс хамгийн баян нь байх болно, учир нь та нар үүрд мөнхийн баялгуудтай

30a су Мэргэн ухаан.

б ИС—А 1:37.

31a 2 Петр 3:14.

32a С ба Г 37:3.

б С ба Г 42.

в Лук 24:49;

С ба Г 39:15; 95:8;

110:9–10.

33a су Номлолын ажил.

б Иса. 45:17;

Иер. 30:10;

С ба Г 136:22.

в Дан. 4:35.

34a су Нийтийн дэмжлэг.

35a су Халамж.

38a су Хишиг (индаумент).

39a Иаков 2:17–19;

С ба Г 11:7.

байх болно; мөн өгөгдөх дэлхийн ^ббаялгууд минийх байх нь зайлшгүй шаардлагатай бөлгөө; гэвч та нар эртний ^анифайчуудын адил болохгүйн тулд ^вбардамналаас болгоомжлогтун.

40 Мөн дахин, би та нарт хэлнэ, хүн бүр, ахлагч, санваартан, багш мөн тэрчлэн гишүүн аль аль нь миний зарлигласан зүйлүүдэд бэлтгэж мөн биелүүлэхийн тулд өөрийн чадалтайгаар, өө-

рийн “гарын хөдөлмөртэйгөөр явагтун хэмээх зарлигийг би өгье.

41 Мөн та нарын “номлол хүн болгон хөршдөө эвтэй зөөлөн хийгээд номхон дөлгөөн байдалд ^бсэрэмжлүүлэх дуу хоолой байг.

42 Мөн та нар ёс бусчуудын дундаас “гарч явагтун. Өөрсдийгөө аврагтун. Их Эзэний сав тээгчид та нар цэвэр ариун байгтун. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 39

1831 оны нэгдүгээр сарын 5-нд Нью-Йоркийн Фейеттед Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Жеймс Ковиллд өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:143–145). Доч орчим жил Баптист тохинуулагч байсан Жеймс Ковилл, Бошиглогч Иосефоор дамжуулан Их Эзэнээс түүнд өгч болох аливаа зарлигийг тэрээр дагах болно хэмээх гэрээнд Их Эзэнтэй оржээ.

1–4, Бурханы хөвгүүд болох хүч Гэгээнтнүүдэд буй; 5–6, Сайн мэдээг хүлээн авна гэдэг нь Христийг хүлээн авна гэсэн үг; 7–14, Баптизм хүртэж мөн Их Эзэний талбайд хөдөлмөрлөхийг Жеймс Ковиллд зарлиг болгов; 15–21, Их Эзэний үйлчлэгчид Хоёрдахь Ирэлтийн өмнө сайн мэдээг номлох ёстой; 22–24, Сайн мэдээг хүлээн авдаг тэд энэ амьдралд болон үүрд мөнхөд цуглуулагдах болно.

АНХААРАГТУН, мөн дуу-Алагтун бүх “үүрд мөнхөөс бүх үүрд мөнхөд байдаг түүний, Агуу ^бБи Байдаг, бүр Есүс Христийн дуу хоолойг —

2 Дэлхийн “гэрэл ба амьдрал, харанхуйд гялалзагч гэрэл мөн харанхуй нь түүнийг ухаарах нь үгүй бөлгөө;

3 Цаг хугацааны “голчид өөрийнхөндөө ирсэн тэр буюу, мөн өөрийнхөн маань намайг хүлээн авсангүй;

39б Хар. 2:8.
 в Моро. 8:27.
 г су Бардамнал.
 40а 1 Кор. 4:12.
 41а су Номлох.
 б су Сэрэмжлэх,

Сэрэмжлүүлэг.
 42а Иса. 52:11.
 39 1а Евр. 13:8;
 С ба Г 20:12;
 35:1; 38:1–4.
 б Ег. 3:14.

су Иехова.
 2а су Гэрэл, Христийн гэрэл.
 3а С ба Г 20:26;
 Мосе 6:57, 62.

4 Харин намайг хүлээн авсан болгонд, миний “хөвгүүд болох хүчийг би өгсөн билээ; мөн бибээр бүр үүнчлэн намайг хүлээн авах болгонд миний хөвгүүд болох хүчийг өгөх болно.

5 Мөн үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, миний сайн мэдээг хүлээн авдаг тэрээр намайг “хүлээн авдаг; мөн миний сайн мэдээг эс хүлээн авдаг тэрээр намайг хүлээн авдаггүй болой.

6 Мөн наманчлал мөн усаар баптисм хүртэх мөн тэгээд галын “баптисм мөн Ариун Сүнс, бүр бүх зүйлийг үзүүлдэг, мөн хаант улсын амар амгалангийн зүйлүүдийг ^азаадаг Тайтгаруулагч ирэх нь — энэ нь миний ^асайн мэдээ бөлгөө.

7 Мөн эдүгээ, болгоогтун, миний үйлчлэгч “Жеймс чамд би хэлж байна, бибээр чиний ажлуудыг харсаар ирсэн мөн бибээр чамайг мэдэх билээ.

8 Мөн үнэнээр би чамд хэлнэ, энэ цаг мөчид зүрх сэтгэл чинь одоо миний өмнө зөв байна; мөн, болгоогтун, тэргүүн дээр чинь агуу адислалуудыг бибээр хүртгээлээ;

9 Гэсэн хэдий ч, чи агуу их уй гашууг үзсэн болой, учир нь чи бардамнал хийгээд ^адэлхийд санаа тавьсны ул-

маас намайг олон удаа эсэргүүцсэн бөлгөө.

10 Гэвч, болгоогтун, хэрэв чи: Босогтун мөн “баптисм хүрт, мөн миний нэрийг дуудан, нүглүүдээ угааж арилгагтун мөн чи миний Сүнсийг, мөн чи хэзээ ч мэдээгүй тийм агуу адислалыг хүлээж авах болно хэмээн хэлэх миний дуу хоолойг сонсох аваас, чиний чөлөөлөлтийн өдрүүд ирэх болно.

11 Мөн хэрэв чи үүнийг хийх аваас, би чамайг илүү агуу их ажлын төлөө бэлтгэсэн ажгуу. Эдгээр эцсийн өдрүүдэд миний урагш илгээсэн миний сайн мэдээний бүрэн байдлыг, Израилын угсаа болох өөрийнхөө хүмүүсийг ^аэргүүлэн олж авахын тулд миний урагш илгээсэн тэрхүү гэрээг чи номлох ёстой.

12 Мөнхүү улиран тохиох дор чам дээр хүч ^абайх болно; чамд агуу итгэл байх болно, мөн бибээр чамтай хамт байж мөн нүүрний чинь өмнө явах болно.

13 Чибээр миний талбайд ^ахөдөлмөрлөхөөр, мөн миний сүмийг өсгөн бэхжүүлэхээр, мөн энэ нь толгодын дээр баясч мөн ^бцэцэглэн хөгжиж болохын тулд Сионыг ^аурагш авчрахаар дуудагдсан болой.

4а Иохан 1:12.
сү Бурханы
хөвгүүд охид.

5а Иохан 13:20.

6а сү Дахин төрөх,
Бурханаас төрөх;
Ариун Сүнс.

б С ба Г 42:61.

в сү Баптисм,

Баптисм хүртээх;
Сайн мэдээ;
Наманчлах,
Наманчлал.

7а С ба Г 40:1.

9а Мат. 13:22.

10а С ба Г 40:1–3.

сү Баптисм,

Баптисм хүртээх.

11а сү Израил—
Израилын
цугларалт.

12а 2 Кор. 12:9.

13а Мат. 20:1–16.

б С ба Г 117:7.

в Иса. 52:8.

14 Болгоогтун, үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, чи дорнын мужууд уруу явахаар дуудагдсан бус харин чи Огайо уруу явахаар дуудагдсан бөлгөө.

15 Мөн миний хүмүүс өөрсдийгөө Огайод цуглуулахын хэрээр хүмүүний үрсийн дунд мэдэгдээгүй тийм “адислалыг би нөөцөнд байлгасаар байх авай, мөн энэ нь тэдний тэргүүн дээр юүлэгдэх болно. Мөн тэр үеэс хойш хүмүүс ⁶бүх “үндэстнүүд уруу урагш явсаар байх болно.

16 Болгоогтун, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, үндэстнүүд дээрх шүүлтээ намайг татан авах болно хэмээн Огайо дахь хүмүүс бодож, их итгэлд намайг дууднам, гэвч би үгээ үгүйсгэж чадахгүй.

17 Иймийн тул бүх хүчээрээ тавигтун мөн энэ нь сүүлчийн удаа “тайрагдаж болохын тулд итгэлтэй хөдөлмөрлөгчдийг миний талбайд дуудагтун.

18 Мөн тэд наманчилж мөн миний сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авч мөн цэвэршигдэхийн хэрээр, мөн

бибээр мутраа “шүүлтэд байлгах болно.

19 Иймийн тул, чанга дуу хоолойгоор хашгиран, өгүүлж: Тэнгэрийн хаант улс ойрхон байна; Хосанна! Бүхний Дээд Бурханы нэр адислагдах болтугай хэмээн хашгиран, урагш одогтун.

20 Миний “ирэлтийн цагт зориулж миний нүүрний өмнөх замыг бэлтгэн, баптисм хүртгээж урагш одогтун;

21 Учир нь тэр цаг ойрхон байна; уг “өдөр буюу цагийг хүмүүн ⁶мэдэх нь үгүй; гэвч энэ нь гарцаагүй тохиох болно.

22 Мөн эдгээр зүйлүүдийг хүлээн авдаг тэрээр намайг хүлээн авдаг; мөн тэд энэ амьдралд болон үүрд мөнхөд надад цуглуулагдах болно.

23 Мөн дахин, мөнхүү улиран тохиох дор, та нарын усаар баптисм хүртгээх болгон дээр та нар “гараа тавин, мөн тэд Ариун Сүнсний ⁶бэлгийг хүлээн авах болно, мөн миний “ирэлтийн тэмдгүүдийг ‘ширтэн хүлээх болно, мөн намайг мэдэх болно.

24 Болгоогтун, би гэнэт ирнэ. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 40

1831 оны нэгдүгээр сард Нью-Йоркийн Фейеттед Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон хоёрт өгөгдсөн илчлэлт оршивой (History of the

15a С ба Г 38:32;
95:8; 110:8–10.
б С ба Г 1:2.
в су Номлолын ажил.
17a Иаков 5:61–75;
С ба Г 24:19.

18a су Есүс Христ—Шүүгч.
20a су Есүс Христийн Хоёр дахь Ирэлт.
21a Мат. 24:36.
б ИС—А 1:40.
23a су Гар тавих.

б су Ариун Сүнсний бэлэг.
в 2 Петр 3:10–14.
г Илч. 3:3;
С ба Г 35:15;
45:39–44.

Church, 1:145). Энэхүү илчлэлтийн цэдгийн өмнө Бошиглогч бичихдээ, “Жеймс Ковилл Их Эзэний үгийг эсэргүүцэж, мөн өөрийнхөө урьдын зарчмууд хийгээд хүмүүст эргэж очиход, Сидней Ригдон бид хоёрт Их Эзэн дараах илчлэлтийг өгсөн бөлгөө” гэжээ (History of the Church, 1:145).

1–3, Мөрдлөг хавчлагаас айх хийгээд дэлхийд санаа тавих нь сайн мэдээг эсэргүүцэхэд хүргэдэг.

БОЛГООГТУН, үнэнээр би та нарт хэлнэ, миний үйлчлэгч “Жеймс Ковиллын зүрх сэтгэл миний өмнө зөв байсан билээ, учир нь тэр миний үгийг дуулгавартай дагана хэмээх гэрээнд надтай орсон бөлгөө.

2 Мөн тэрээр үгийг баяр-

тайгаар “хүлээн авсан билээ, гэвч Сатан тэр даруйд түүнийг уруу татжээ; мөн мөрдлөг хавчлагаас айсан хийгээд дэлхийд санаа тавьсан нь үгийг “эсэргүүцэхэд түүнийг хүргэжээ.

3 Иймийн тул тэрээр миний гэрээг зөрчив, мөн надад сайн санагдсанаар түүнд үйлдэх нь надад үлддэг болой. Амен.

ХЭСЭГ 41

1831 оны хоёрдугаар сарын 4-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:146–147). Сүмийн Көртланд Салбар энэ үед тоогоороо түргэн өсч байв. Энэхүү илчлэлтийн өмнөх үг болгон Бошиглогч бичихдээ, “Гишүүд . . . тэд Бурханы тааллыг мэдэж байсныхаа хэрээр үүнийг гүйцэлдүүлэхийг хичээж байлаа, хэдий тийм ч зарим хачирхалтай үзэл санаанууд мөн хуурмаг сүнснүүд тэдний дунд сэм шургалжээ . . . [мөн] Их Эзэн Сүмд дараах зүйлийг өгчээ” (History of the Church, 1:146–147).

1–3, Илчлэлтийн сүнсээр ахлагч нар Сүмийг эрхлэх болно; 4–6, Үнэнч шавь нар Их Эзэний хуулийг хүлээн авч мөн сахих болно; 7–12, Эдвард Партриж Сүмд бишопоор томилогдов.

АНХААРАГТУН мөн сонс, Ай, миний хүмүүс, хэмээн та нарын Бурхан, Их Эзэн хэлнэм, та нарыг бүх адислалуудын хамгийн агуугаар нь “адислахдаа баяртай байна

40 1a С ба Г 39:7–11.
2a Марк 4:16–19.
б Мат. 13:20–22.

су Хавчих,
Хавчлага.
в су Урвалт.

41 1a су Адислах,
Адислагдах,
Адислал.

би, намайг сонсдог нь та нар бөлгөө; мөн намайг эс сонсох та нарыг, миний нэрийг ^бхүлээн зөвшөөрдөг мэт дүр эсгэгч та нарыг бүх зүхлүүдээс хамгийн хүндээр нь ^бзүхэх болно би.

2 Анхаарагтун, Ай миний дуудсан сүмийн минь ахлагчид, болгоогтун миний үгэнд ^бсанал нэгтэй байхын тулд өөрсдийгөө цуглуул хэмээх зарлигийг та нарт өгч байна би;

3 Мөн та нар миний сүмийг хэрхэн эрхлэхээ мэдэж мөн бүх зүйлийг миний өмнө зөвөөр байлгахын тулд та нар итгэлийнхээ залбирлаар миний ^бхуулийг хүлээн авах болно.

4 Мөн бибээр ^бирэхдээ та нарын ^бжолоодогч байх болно; мөн болгоогтун, би гэнэт ирнэ, мөн та нар миний хууль сахигдахыг мэдэгтүн.

5 Миний хуулийг ^бхүлээн авч мөн үүнийг ^бүйлддэг тэр нь миний шавь болой; мөн үүнийг хүлээн авдаг хэмээн хэлдэг атлаа мөн үүнийг эс хийдэг мөнөөх тэр нь миний шавь биш болой, мөн та нарын дундаас ^бзайлуулагдах ёстой;

6 Учир нь хаант улсын хүүхдүүдэд хамааралтай зүйлүүд зохисгүй тэдэнд, эсвээс ^бнохдод өгөгдөх буюу, гахайн өмнө ^бсувднууд хаягдах нь зүйд үл нийцэх бөлгөө.

7 Мөн дахин, миний үйлчлэгч Бага Иосеф Смит амьдрах мөн ^борчуулах ^ббайр бариулах ёстой нь зүйд нийцэх бөлгөө.

8 Мөн дахин, миний үйлчлэгч Сидней Ригдон миний зарлигуудыг сахьж, түүнд сайн санагдсанаар амьдрах ёстой нь зүйд нийцэх авай.

9 Мөн дахин, би өөрийн үйлчлэгч ^бЭдвард Партрижийг дуудсан билээ; мөн худалдаа наймааныхаа ажлыг орхиод мөн бүх цагаа сүмийн хөдөлмөрүүдэд ^бзориулахын тулд тэрээр сүмийн дуу хоолойгоор томилогдох, мөн сүмд ^ббишопоор томилогдох ёстой хэмээх зарлигийг би өгч байна;

10 Миний хуулиудад энэ нь түүнд өгөгдөх тэрхүү хуулиудыг бибээр өгөх тэр өдөр тэрбээр бүх зүйлд санаа тавих ёстой.

11 Мөн энэ нь түүний зүрх сэтгэл миний өмнө цэвэр ариун байгаагийнх билээ,

1б С ба Г 56:1–4;
112:24–26.
в Дэд хууль 11:26–28;
1 Ниф. 2:23.
2а су Эв Нэгдэл.
3а С ба Г 42.
4а су Есүс Христийн
Хоёр дахь Ирэлт.
б Зех. 14:9;
С ба Г 45:59.

су Есүс Христ—
Христийн Мянган
жилийн хаанчлал.
5а Мат. 7:24.
б Иаков 1:22–25;
С ба Г 42:60.
в С ба Г 50:8–9.
су Сүмээс хөөх.
6а Мат. 15:26.
б Мат. 7:6.

7а ө.х. Библийг
орчуулах.
С ба Г 45:60–61.
б С ба Г 42:71.
9а С ба Г 36:1.
б С ба Г 51.
в С ба Г 72:9–12;
107:68–75.
су Бишоп.

учир нь дотроо “заль мэхгүй эртний” Натаньелтэй тэрээр адил болой.

12 Эдгээр үгс та нарт өгөгдсөн, мөн тэдгээр нь миний өмнө цэвэр ариун болой;

иймийн тул, тэдгээрийг хэрхэн авч үзэх тухайд та нар болгоомжил, учир нь тэдгээр нь шүүлтийн өдөр та нарын бодгалиудад хариулагдах ёстой. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 42

1831 оны хоёрдугаар сарын 9-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:148–154). Энэ нь арванхоёр ахлагчийн дэргэд мөн Огайод “хууль” өгөгдөхөөр урьд нь Их Эзэний өгсөн амлалтын биелэлт болон хүлээн авагдсан ажээ (Хэсэг 38:32-ыг үз). Бошиглогч энэхүү илчлэлтийг “Сүмийн хуулийг агуулдаг” хэмээн онцлон тэмдэглэжээ (History of the Church, 1:148).

1–10, Ахлагчид сайн мэдээг номлох, хөрвөгчдэд баптисм хүртээх, мөн Сүмийг байгуулахаар дуудагдав; 11–12, Тэд дуудагдаж мөн томилогдон, судруудад байдаг сайн мэдээний зарчмуудыг заах ёстой; 13–17, Тэд Сүнсний хүчээр зааж бас бошиглох ёстой; 18–29, Хүн алахгүй, хулгай хийхгүй, худал хэлэхгүй, тачаадахгүй, садар самууныг үйлдэхгүй, эсвээс бусдын эсрэг муугаар ярихгүй байхыг Гэгээнтнүүдэд зарлиглав; 30–39, Өмч хөрөнгийн өргөлийг зохицуулах хуулиуд толилуулагдав; 40–42, Бардамнал хийгээд залхуурал буруушаагдах авай; 43–52, Адислалаар дамжуулан мөн итгэлээр өвчтөнүүд эдгэрэх ёстой; 53–60, Судрууд Сүмийг чиглүүлэх бөгөөд дэлхийд тунхаглагдах ёстой; 61–69, Шинэ Иерусалимын газар хийгээд хаант улсын нууцууд илчлэгдэх болно; 70–73, Өргөл болгогдсон өмч хөрөнгөнүүд Сү-

мийн ажилтнуудыг дэмжихэд ашиглагдах ёстой; 74–93, Садар самуун, завхайрал, хүн алах, хулгайлах, мөн нүглүүдийн гэмшилийг зохицуулах хуулиуд толилуулагдав.

АНХААРАГТУН, бүр Есүс Христ, амьд Бурханы Хүү, дэлхийн Аврагч миний нэрэнд өөрсдийгөө цуглуулсан Ай миний сүмийн ахлагчид та нар; учир нь та нар миний нэрэнд итгэж мөн зарлигуудыг минь сахьдагийнх болой.

2 Дахин би та нарт хэлнэ, та нарт миний өгөх “хуулийг анхаарагтун мөн сонс мөн дуулгавартай дагагтун.

3 Учир нь үнэнээр би хэлнэ, та нарт миний зарлигласан тэрхүү “зарлигийн дагуу та нар өөрсдийгөө цуглуулсан учраас, мөн энэ нэг зүйлийн талаар ^бсанал нэгтэй байж, мөн миний нэрээр Эцэгээс

асуулаа, бүр үүнчлэн та нар хүлээн авах болно.

4 Болгоогтун, үнэнээр би та нарт хэлнэ, миний үйлчлэгчид Бага Иосеф Смит, Сидней Ригдон хоёроос бусад та нар нэг бүрчлэн миний нэрээр урагш одох болно хэмээх энэхүү анхны зарлигийг би та нарт өгч байна.

5 Мөн тэд богинохон хугацаанд урагш одох болно, мөн хэзээ тэд эргэж ирэх нь “Сүнсний хүчээр өгөгдөх болно хэмээх зарлигийг би тэдэнд өгч байна.

6 Мөн та нар миний сайн мэдээг номлож, “хоёр хоёроороо, миний нэрээр, бүрэн дуу мэт дуу хоолойгоо өргөн, Бурханы тэнгэр элчүүд адил миний үгийг тунхаглан миний Сүнсний хүчээр урагш одох ёстой.

7 Мөн та нар усаар баптисм хүртээж: Наманчлагтун та нар, наманчлагтун та нар, учир нь тэнгэрийн хаант улс ойрхон байна хэмээн хэлж, урагш одох ёстой.

8 Мөн энэ газраас та нар өрнөд тийшээ бүс нутгууд уруу урагш одох ёстой; мөн та нарыг хүлээн авах тэднийг та нар олохын хэрээр та нар бүс нутаг болгонд

миний сүмийг өсгөн бэхжүүлэх ёстой—

9 Та нар нэгд “цугларсан байж болохын тулд, миний хүмүүс байж мөн бибээр та нарын Бурхан байж болохын тулд, “Шинэ Иерусалим” хот хэзээ бэлтгэгдэх нь тэнгэрээс та нарт илчлэгдэх тэр үеийг хүртэл буюу.

10 Мөн дахин, би та нарт хэлнэ, миний үйлчлэгч “Эдвард Партриж, өөрийг нь миний томилсон тэрхүү албан тушаалд үүргээ биелүүлэх ёстой. Мөнхүү улиран тохиох дор, хэрэв тэрээр зөрчил гаргах аваас “өөр нэгэн нь түүний оронд томилогдох болно. Бүр тийм буюу. Амен.

11 Дахин би та нарт хэлье, “эрх мэдэл бүхий хэн нэгнээр” томилогдсон, мөн тэрээр эрх мэдэлтэй, бас сүмийн тэргүүнүүдээр зохих ёсоор тэрээр томилогдсон гэдэг нь сүмд мэдэгдэхээс бусдаар миний сайн мэдээг “тунхаглах, эсвээс миний сүмийг өсгөн бэхжүүлэхээр урагш одох нь хэнд ч өгөгдөх ёсгүй.

12 Мөн дахин, энэ сүмийн “ахлагчид, санваартнууд хийгээд багш нар” Библи хийгээд “сайн мэдээний бүрэн бай-

5а су Ариун Сүнс.

6а Марк 6:7.

су Номлолын ажил.

9а су Израил—

Израилын цугларалт.

б Зех. 8:8.

в Ифер 13:2–11;

С ба Г 45:66–71;

84:2–5; Мосе 7:62;

ИТ 1:10.

су Шинэ Иерусалим.

г С ба Г 57:1–2.

10а С ба Г 41:9–11; 124:19.

б С ба Г 64:40.

11а су Эрх мэдэл;

Санваартан.

б су Дуудах,

Бурханаас

дуудагдах,

Дуудлага; Томилох,

Томилолт.

в су Номлох.

12а су Ахлагч.

б су Библи.

в су Сайн мэдээ.

дал байгаа “Мормоны Номон дахь, миний сайн мэдээний зарчмуудыг ^азаах ёстой.

13 Мөн тэд гэрээнүүд хийгээд сүмийн тунхгуудыг биелүүлэхийн тулд анхааралтайгаар дагах ёстой, мөн эдгээр нь тэд Сүнсээр чиглүүлэгдэх үед тэдний заадаг зүйлүүд байх ёстой.

14 Мөн уг Сүнс итгэлийн “залбирлаар та нарт өгөгдөх болно; мөн хэрэв та нар ^бСүнсийг эс хүлээн авбаас та нар заах нь үгүй.

15 Мөн миний “судруудын бүрэн байдал өгөгдөх хүртэл, та нарын заалтын талаар миний зарлигласны адил, энэ бүхнийг та нар анхааралтай дагах ёстой.

16 Мөн та нар “Тайтгаруулагчаар дуу хоолойгоо өргөх үед, та нар надад сайн санагдсанаар ярьж мөн бошиглох болно;

17 Учир нь, болгоогтун, Тайтгаруулагч бүх зүйлийг мэддэг, мөн Эцэгийн тухай мөн Хүүгийн тухай гэрчилдэг бөлгөө.

18 Мөн эдүгээ, болгоогтун, бибээр сүмд ярьж байна. Чи “хүн алах ёсгүй; мөн ^бхүн

алсан түүнд энэ дэлхийд ч, мөн ирэх дэлхийд ч өршөөл үгүй болой.

19 Мөн дахин, би хэлж байна, чи хүн алах ёсгүй; харин хүн алсан тэрээр “үхэх ёстой.

20 Чи “хулгайлах ёсгүй; мөн хулгайлдаг мөн үл наманчилдаг тэрээр зайлуулагдах ёстой.

21 Чи “худал хэлэх ёсгүй; худал хэлдэг мөн үл наманчилдаг тэрээр зайлуулагдах ёстой.

22 Чи эхнэрээ бүх зүрх сэтгэлээрээ “хайрлаж мөн өөр хэнтэй ч биш харин түүнтэй ^бнэгдэн нийлэх ёстой.

23 Мөн эмэгтэй хүнийг “тачаангуйгаар хардаг тэрээр итгэлийг үгүйсгэнэ, мөн Сүнстэй байх нь үгүй болно; мөн хэрэв тэрээр үл наманчилбаас тэрээр зайлуулагдах ёстой.

24 Чи “садар самууныг үйлдэх ёсгүй; мөн садар самууныг үйлддэг, мөн үл наманчилдаг тэрээр зайлуулагдах ёстой.

25 Гэвч садар самууныг үйлдсэн тэрээр мөн бүх зүрх сэтгэлээрээ “наманчилж, мөн үүнийг орхиж, тэгээд үүнийг

12г су Мормоны Ном;

Судрууд—

Судруудын үнэ цэнэ.

д Мозая 18:19–20;

С ба Г 52:9, 36.

су Заах, Багш.

14а С ба Г 63:64.

су Залбирал.

б су Ариун Сүнс;

Заах, Багш—

Сүнсээр Заах.

15а С ба Г 42:56–58.

16а 1 Кор. 2:10–14;

С ба Г 68:2–4.

су Тайтгаруулагч.

18а Ег. 20:13–17;

Мат. 5:21–37;

2 Ниф. 9:35;

Мозая 13:21–24;

3 Ниф. 12:21–37.

б су Аллага.

19а су Үхлийн шийтгэл.

20а су Хулгай хийх,

Хулгай.

21а су Үнэнч, Үнэнч

шударга; Худал хэлэх.

22а су Хайр; Гэрлэлт, Гэрлэх.

б Эхл. 2:23–24;

Ефес 5:25, 28–33.

23а Мат. 5:28;

3 Ниф. 12:28;

С ба Г 63:16.

су Тачаадах.

24а су Завхайрал.

25а су Наманчлал,

Наманчлал.

дахиад эс үйлдвээс, чи ^бууч-
лах ёстой;

26 Гэвч хэрэв тэрээр үүнийг
“дахин үйлдвээс, тэрээр ууч-
лагдах нь үгүй, харин зай-
луулагдах ёстой.

27 Чи хөршийнхөө талаар
“шүүмжлэх буюу түүнд али-
ваа хор хөнөөл учруулах ёсгүй.

28 Эдгээр зүйлүүдийн та-
лаарх миний хуулиуд суд-
руудад минь өгөгдсөнийг чи
мэдэх бөлгөө; нүгэл үйлддэг
мөн үл наманчилдаг тэрээр
“зайлуулагдах ёстой.

29 Хэрэв чи намайг “хайрла-
даг бол чи надад ^бүйлчилж
мөн бүх зарлигуудыг минь
“сахих ёстой.

30 Мөн болгоогтун, чи “ядуу-
сыг санаж, мөн чи тэдэнтэй
хуваалцах ёстой өөрийнхөө
өмч хөрөнгийг тэднийг ^бдэм-
жихийн тулд, зөрчиж үл бо-
лох гэрээгээр мөн шилжүү-
лэх эрхийн бичгээр “ариулан
адислах ёстой.

31 Мөн та нар эд юмсаа
“ядуустай ^бхуваалцсанаар, та
нар үүнийг надад үйлдэх
болно; мөн тэдгээр нь миний
сүмийн “бишоп хийгээд түү-
ний томилдог, эсвээс томил-
сон, мөн тэрхүү зорилгын
учир ‘онцгойлон адисалсан

түүний зөвлөхүүд болох хоёр
ахлагч буюу дээд санваарт-
нуудын өмнө тавигдах ёстой.

32 Мөнхүү улиран тохиох
дор, тэдгээр нь миний сү-
мийн бишопын өмнө тавигд-
саны дараа мөн миний зар-
лигуудын дагуу тэдгээр нь
сүмээс авагдахгүй гэсэн, ми-
ний сүмд өмч хөрөнгө “өргөл
болгосон тухай эдгээр гэрч-
лэлүүдийг тэрээр хүлээн
авсны дараа, хүн болгон өө-
рийнхөө өмч хөрөнгө буюу
өргөлөөр өөртөө болон ^бтэр
бүлдээ хүрэлцэхүйц хэмжээ-
тэйгээр хүлээн авсан тэр зүй-
лийнхээ “даамал байж, миний
өмнө ‘хариуцлага хүлээхээр
болгогдох ёстой.

33 Мөн дахин, хэрэв сүмийн,
эсвээс үүний аливаа нэг хувь
хүмүүсийн гарт анхны энэ-
хүү өргөлийн дараа тэднийг
дэмжихэд зайлшгүй шаард-
лагатайгаас “илүү өмч хөрөн-
гө байх аваас, энэ нь өргөл
болгогдохын тулд бишопт
үлдэж, гачигдалтай хүн бол-
гон хүрэлцэхүйц хэмжээ-
гээр хангагдаж мөн хүслүү-
дийнхээ дагуу хүлээн авч
болохын тулд байхгүй тэ-
дэнд цагаас цагт өгөхөөр энэ
нь хадгалагдах ёстой.

25б Иохан 8:3–11.

су Уучлах.

26а 2 Петр 2:20–22;

С ба Г 82:7.

27а су Хов жив.

28а су Сүмээс хөөх.

29а Иохан 14:15, 21.

б су Үйлчлэл.

в су Дуулгавартай

байх, Дуулгавар-

тай, Дуулгавартай

дагах.

30а Мозая 4:16–26;

Алма 1:27.

су Ядуус.

б су Халамж.

в су Өргөл болгох,

Өргөлийн хууль.

31а су Ядуу.

б Мозая 2:17.

су Өглөг, Өглөг

өгөх.

в су Бишоп.

г су Онцгойлон

адислах.

32а С ба Г 51:4.

б С ба Г 51:3.

в су Даамал, Ажил

Үүрэг.

г С ба Г 72:3–11.

су Хариуцах,

Хариуцлага,

Хариуцлагатай.

33а С ба Г 42:55; 51:13;

119:1–3.

34 Тиймийн тул, үлдсэн нь сүмийн дээд зөвлөл, мөн бишоп хийгээд түүний зөвлөлийн чиглүүлснээр ядуус хийгээд гачигдагсаад өгөхийн тул миний агуулахад хадгалагдах ёстой;

35 Мөн сүмийн нийтийн ашиг тусын тулд, мөн шүтээний барилгуудыг барих, мөн үүнээс хойш илчлэгдэх “Шинэ Иерусалимыг барихын тулд газруудыг худалдан авах зорилгын тулд юм —

36 “Ариун сүмдээ миний ^бирэх тэр өдөр миний гэрээт хүмүүс нэгд цугларсан байж болохын тулд болой. Мөн бибээр үүнийг өөрийн хүмүүсийн авралын тулд хийдэг.

37 Мөнхүү улиран тохиох дор, нүгэл үйлддэг мөн үл наманчилдаг тэрээр сүмээс “зайлуулагдах ёстой, мөн миний сүмийн ядуус хийгээд гачигдалтай тэдэнд, өөрөөр хэлбэл, надад ^бариулан адисалснаа тэрээр буцааж авахгүй байх болно —

38 Учир нь та нар үүнийг эдний хамгийн дордод нь хийснээр та нар үүнийг надад “хийх болно.

39 Учир нь мөнхүү улиран тохиох дор, бошиглогчдынхоо амаар миний хэлсэн нь биелэгдэх болно; учир нь

Харийнханы дундаас миний сайн мэдээг гэврэн авах тэдний баялгуудыг Израилын угсаа болох миний хүмүүсийн ядууст би өргөл болгох болно.

40 Мөн дахин, чи зүрх сэтгэлдээ “бардам байх ёсгүй; бүх ^бөмсгөлүүдээ энгийн даруу байлгагтун, мөн тэдгэрийн сайхан нь чиний гарын ажлын сайхан юм;

41 Мөн бүх зүйл миний өмнө цэвэр ариун байдалд хийгдэг.

42 Чи “залхуу байх ёсгүй; учир нь залхуу тэрээр хөдөлмөрлөгчийн талхыг ч идэх, мөн өмсгөлүүдийг ч өмсөх ёсгүй бөлгөө.

43 Мөн та нарын дундах хэн нэгэн нь “өвчтэй болоод мөн эдгэрэх итгэлгүй харин итгэдэг хэн нь ч гэсэн, бүх өрөвч зөөлөн сэтгэлээр, ургамлаар мөн хөнгөн хоол хүнсээр, мөн энэ нь дайсны гараар бус тэжээгдэх ёстой.

44 Мөн сүмийн ахлагчид хоёр болон түүнээс олон нь дуудагдах ёстой, мөн тэдний төлөө залбирч мөн миний нэрээр тэд “гараа тэдний толгой дээр тавих ёстой; мөн хэрэв тэд нас нөгчих аваас тэд надад ^бнас нөгчих болой, мөн хэрэв тэд амьдрах аваас тэд надад амьдрах болно.

45 Чи “хайранд хамтдаа

35a су Шинэ Иерусалим; Сион.

36a Малах. 3:1.

б С ба Г 36:8.

37a С ба Г 41:5; 50:8–9.

су Сүмээс хөөх.

б су Өргөл болгох, Өргөлийн хууль.

38a Мат. 25:34–40.

су Энэрэл; Халамж.

40a Сур. үгс 16:5.

су Бардамнал.

б су Төлөв зан.

42a С ба Г 68:30–32.

су Залхуурах, Залхуу байдал.

43a су Өвчтэй, Өвчин.

44a су Өвчтөнийг

эдгээх; Гар тавих.

б Ром. 14:8;

Илч. 14:13;

С ба Г 63:49.

45a су Хайр.

^бамьдрах ёстой, ийнхүү чи нас нөгчсөн тэднийг алдсаныхаа төлөө мөн нэн ялангуяа эрхэм сайхан амилуулалтад ^бнайдваргүй тэдний төлөө ^вуйлах ёстой.

46 Мөнхүү улиран тохиох дор надад нас нөгчсөн тэд “үхлийг үл амсана, учир нь энэ нь тэдэнд ^бтааламжтай байх болно;

47 Мөн надад нас нөгчөөгүй тэд, халаг тэдэнд, учир нь тэдний үхэл гашуун болой.

48 Мөн дахин, мөнхүү улиран тохиох дор надад “эдгэрэх ^битгэлтэй, мөн үхэлд ^боноогдоогүй тэр нь эдгэрэх болно.

49 Харах итгэлтэй тэр нь харах болно.

50 Сонсох итгэлтэй тэр нь сонсох болно.

51 Үсрэх итгэлтэй хазгар нь үсрэх болно.

52 Мөн эдгээр зүйлийг хийх итгэлгүй атлаа надад итгэдэг тэд миний “хөвгүүд болох хүчтэй байна; мөн тэд миний хуулиудыг зөрчихгүй байхын хэрээр чи тэдний ёс суртахууны сул дорой байдлыг ^бүүрэх болно.

53 Чи “ажил үүргийнхээ газарт зогсох ёстой.

54 Чи ахынхаа өмсгөлийг авах ёсгүй; чи ахаасаа хүлээн авсан зүйлийнхээ төлөө чи төлөх ёстой.

55 Мөн хэрэв чи өөртөө дэмжлэг болохоос илүүг “олж авбал, бүх зүйл миний хэлсний дагуу хийгдэж болохын тулд чи үүнийг миний ^багуулахад өгөх ёстой.

56 Чи асуух ёстой, мөн миний “судрууд миний тогтоосончлон өгөгдөх болно, мөн тэдгээр нь найдвартай ^бхадгалагдах ёстой;

57 Мөн тэдгээрийн талаар чи дуугүй байх ёстой нь, мөн чи тэдгээрийг бүрэн дүүрнээр нь хүлээн авах хүртлээ тэдгээрийг заахгүй байх нь зүйтэй болой.

58 Мөн дараа нь бүх хүмүүнд тэдгээрийг та нар заах ёстой хэмээх зарлигийг би та нарт өгч байна; учир нь “бүх үндэстэн, ястан, хэлтнүүд хийгээд хүмүүст тэдгээр нь заагддаг байх ёстой.

59 Миний сүмийг эрхлэх хууль байхаар миний судруудад хууль болон чамд өгөгдсөн, хүлээн авсан зүйлүүдээ чи анхааралдаа авах ёстой;

60 Мөн эдгээр зүйлүүдийн дагуу “үйлддэг тэрээр авраг-

45б 1 Иохан 4:16, 20–21.

в 1 Кор. 15:19–22.

сү Найдвар.

г Алма 28:11–12.

46а сү Биенийн үхэл.

б Илч. 14:13.

48а сү Эдгээх, Эдгэрэх.

б С ба Г 46:19.

сү Итгэл.

в Ном. үгс 3:1–2;

Үйлс 17:26;

Евр. 9:27;

С ба Г 122:9.

52а сү Бурханы

хөвгүүд охид.

б Ром 15:1.

сү Нөхөрлөл.

53а сү Даамал, Ажил

үүрэг.

55а С ба Г 82:17–19;

119:1–3.

б С ба Г 42:34; 51:13.

56а Библийн

Орчуулганд үг

оруулах.

С ба Г 45:60-61.

б сү Судрууд—

Судруудын үнэ цэнэ.

58а С ба Г 1:2.

60а С ба Г 41:5.

сү Дуулгавартай

байх, Дуулгавар-

тай, Дуулгавартай

дагах.

дах болно, мөн тэдгээрийг үл үйлддэг тэрээр хэрэв үүнчлэн үргэлжлүүлсээр байх аваас ^бяллагдах болно.

61 Хэрэв чи асуух аваас, чи “баяр хөөрийг авчирдаг, амьдралыг авчирдаг тэрхүү ^бнууцууд хийгээд “амар ам-галангийн зүйлүүдийг мэдэж болохын тулд ‘илчлэлт дээр илчлэлт мэдлэг дээр ^дмэдлэг хүлээн авах болно.

62 Чи асуух ёстой, мөн “Шинэ Иерусалим хаана баригдах ёстой нь миний тогтоосон цагт чамд илчлэгдэх болно.

63 Мөн болгоогтун, мөнхүү улиран тохиох дор миний үйлчлэгчид дорнодод мөн өрнөдөд, умардад мөн өмнөдөд урагш илгээгдэх болно.

64 Мөн бүр эдүгээ, дорнод уруу явах тэр нь хөрвүүлэгдэх тэдэнд “өрнөд уруу зугтахыг заагтун, мөн энэ нь дэлхий дээр ирж буй тэр зүйлийн, мөн ^бнууц хуйвалдаануудын улмаас болой.

65 Болгоогтун, та нар эдгээр бүх зүйлийг анхааралтай дагах ёстой, мөн шагнал чинь агуу байх бөлгөө; учир нь хаант улсын нууцуудыг мэдэх нь та нарт өгөгддөг, харин

тэдгээрийг мэдэх нь дэлхийд өгөгддөггүй бөлгөө.

66 Та нар хүлээж авсан хуулиудаа анхааралтай дагаж мөн итгэлтэй байх ёстой.

67 Мөн үүнээс хойш та нар энд хийгээд Шинэ Иерусалимын аль алинд нь та нарыг төлөвшүүлэхэд хангалттай байх сүмийн “гэрээнүүдийг хүлээн авах болно.

68 Тиймийн тул, “мэргэн ухаан дутдаг тэрээр надаас асууг, мөн бибээр түүнд чөлөөтэйгээр өгөх болно, мөн түүнийг шүүмжлэх нь үгүй бөлгөө.

69 Зүрх сэтгэлээ өргөж мөн баясагтун, учир нь та нарт “хаант улс, эсвээс өөрөөр хэлбэл, сүмийн ^бтүлхүүрүүд өгөгдсөн бөлгөө. Бүр тийм буюу. Амен.

70 “Санваартнууд хийгээд ^ббагш нар бүр гишүүдийн нэг адил өөрсдийн “ажил үүрэгтэй байх ёстой.

71 Мөн бүхий л зүйлүүдэд бишопт зөвлөхүүд нь байж туслахын тулд томилогддог ахлагчид буюу дээд санваартнуудын гэр бүлүүд ядуусын сайн сайхны төлөө, мөн өмнө дурдсанчлан бусад зорилгуудын төлөө бишопт “ариулан

60*б* Моце 5:15.

су Ял.

61*а* су Баяр баясгалан.

б С ба Г 63:23.

су Бурханы

нууцууд.

в С ба Г 39:6.

г су Илчлэлт.

д Абр. 1:2.

су Мэдлэг;

Гэрчлэл.

62*а* С ба Г 57:1-5.

64*а* С ба Г 45:64.

б су Нууц

хуйвалдаанууд.

67*а* С ба Г 82:11-15.

68*а* Иаков 1:5.

су Мэргэн ухаан.

69*а* су Бурханы хаант

улс буюу

Тэнгэрийн хаант

улс.

б Мат. 16:19;

С ба Г 65:2.

су Санваарын

түлхүүрүүд.

70*а* су Санваартан,

Аароны санваар.

б су Багш, Аароны

санваар.

в су Даамал, Ажил

үүрэг.

71*а* су Өргөл болгох,

Өргөлийн хууль.

адислагдсан өмч хөрөнгөөр тэтгэгддэг байх ёстой;

72 Эсвээс тэд ажил үүрэг буюу өөр байдлаарх бүхий л үйлчлэлүүдийнхээ төлөө хамгийн сайн хэмээн бодогдсоноор эсвээс зөвлөхүүд хийгээд бишопын шийдсэнээр шударга нөхөн төлбөр авах ёстой.

73 Мөн тэрчлэн, өөрийн дэмжлэг буюу сүм дэх бүхий л үйлчлэлүүдийнхээ төлөө бишоп шударга нөхөн төлбөр авах ёстой.

74 Болгоогтун, үнэнээр би та нарт хэлнэ, “завхайрлын шалтгааных нь учир ханиа орхисон та нарын дундах ямар ч хүн, өөрөөр хэлбэл, тэд зүрх сэтгэлийнхээ бүхий л номхон дөлгөөн байдалд энэ нь ийм болохыг та нарын өмнө гэрчилбээс, та нар тэднийг өөрсдийнхөө дундаас зайлуулах ёсгүй;

75 Гэвч “садар самууны улмаас ханиа орхисон аливаа хүмүүсийг та нар мэдэх аваас, мөн тэд өөрсдөө гомдоогчид бөгөөд тэдний хань нь амьд байгаа бол тэд та нарын дундаас “зайлуулагдах ёстой.

76 Мөн дахин, би та нарт хэлж байна хэрэв тэд гэрлэсэн аваас, та нар иймэрхүү хэнийг ч өөрсдийнхөө дунд хүлээн авахгүйн тулд та нар тодорхой мэдэж аван, “сэрэмжтэй мөн болгоомжтой байгтун;

77 Мөн хэрэв тэд гэрлээгүй аваас, тэд бүхий л нүглүүдээ наманчлах ёстой эсвэл та нар тэднийг хүлээн авах ёсгүй.

78 Мөн дахин, Христийн энэ сүмд харьяалагддаг хүн болгон сүмийн бүх зарлигууд хийгээд гэрээнүүдийг анхааралтай дагах ёстой.

79 Мөнхүү улиран тохиох дор хэрэв та нарын дундах аливаа хүмүүс “хүн алах аваас, тэд уг нутгийн хуулиудын дагуу шилжүүлэн өгөгдөж мөн шийдэгдэх ёстой; учир нь түүнд уучлал үгүй гэдгийг санагтун; мөн энэ нь уг нутгийн хуулиудын дагуу нотлогдох болно.

80 Мөн хэрэв аливаа эрэгтэй эсвэл эмэгтэй садар самууныг үйлдэх аваас, тэрээр сүмийн хоёр буюу түүнээс олон ахлагчийн өмнө шүүгдэх ёстой, мөн түүний талаарх үг бүр нь дайснаар биш, сүмийн хоёр гэрчээр үндэслэгдэх ёстой; харин хэрэв хоёроос илүү гэрч байх аваас энэ нь бүр сайн.

81 Гэвч тэрээр хоёр гэрчийн амаар буруушаагдах ёстой; мөн ахлагчид уг тохиолдлыг сүмийн өмнө тавих ёстой, мөн тэд Бурханы хуулийн дагуу шийдэгддэг байж болохын тулд сүм түүний эсрэг тэдний гарыг өргүүлэх ёстой.

82 Мөн хэрэв энэ нь боломжтой аваас, бишоп тэрчлэн

74a су Садар самуун;
Бэлгийн харилцааны ёс

суртахуунгүй байдал.
75a су Завхайрал.

б су Сүмээс хөөх.
76a су Харах, Харуул.
79a су Аллага.

байлцах нь шаардлагатай бөлгөө.

83 Мөн та нар өөрсдийнхөө өмнө тулгарах бүхий л тохиолдлуудад ийн үйлдэх ёстой.

84 Мөн хэрэв эрэгтэй буюу эмэгтэй хүн дээрэм хийвээс, тэрээр уг нутгийн хуулинд шилжүүлэн өгөгдөх ёстой.

85 Мөн хэрэв тэрээр “хулгайлах аваас тэрээр уг нутгийн хуулинд шилжүүлэн өгөгдөх ёстой.

86 Мөн хэрэв тэрээр “худал хэлэх аваас, тэрээр уг нутгийн хуулинд шилжүүлэн өгөгдөх ёстой.

87 Мөн хэрэв тэрээр аливаа байдлаар алдсыг үйлдвээс, тэрээр хуулинд, бүр Бурханыхад шилжүүлэн өгөгдөх ёстой.

88 Мөн хэрэв “ах буюу эгч чинь чамд ^бгэм бурууг үйлдэх аваас, чи түүнтэй ганцаарчлан уулзах ёстой; мөн тэрээр ^бгэмээ хүлээх аваас чи эвлэрэх ёстой.

89 Мөн хэрэв тэрээр гэмээ үл хүлээх аваас чи түүнийг

сүмд, гишүүдэд бус, харин ахлагчдад шилжүүлэн өгөх ёстой. Мөн энэ нь дэлхийн өмнө биш, харин цуглаан дээр хийгддэг байх ёстой.

90 Мөн хэрэв ах буюу эгч чинь олонд гэм бурууг үйлдэх аваас, тэрээр олны өмнө “гэсгээн цээрлүүлэгдэх ёстой.

91 Мөн хэрэв хэн нэгэн нь олны өмнө гэм бурууг үйлдэх аваас, тэрээр ичгүүрлэгдэж болохын тулд түүнийг олны өмнө зэмлэх ёстой. Мөн хэрэв тэрээр гэмээ үл хүлээх аваас, тэрээр Бурханы хуулинд шилжүүлэн өгөгдөх ёстой.

92 Хэрэв хэн нэгэн нь нууцаар гэм бурууг үйлдэх аваас, тэрээр гэм бурууг үйлдсэн хүндээ мөн Бурханд нууцаар буруугаа хүлээх боломжтой байж болохын тулд, түүний талаар сүм зэмлэнгүйгээр ярихгүй байж болохын тулд, тэрээр нууцаар зэмлэгдэх ёстой.

93 Мөн та нар бүхий л зүйлүүдэд ийнхүү үйлдэх ёстой.

ХЭСЭГ 43

1831 оны хоёрдугаар сард Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:154–156). Энэ үед Сүмийн зарим гишүүд хуурамч илчлэгчийн дүр эсгэдэг байсан хүмүүсээр үймүүлэгдсэн байв. Бошиглогч Их Эзэнээс асууж мөн Сүмийн ахлагч нарт хандсан энэхүү захиасыг хүлээн авсан билээ. Эхний хэсэг нь Сүмийн бодлоготой холбогддог;

85а су Хулгай хийх,
Хулгай.

86а су Үнэнч, Үнэнч
шударга; Худал

хэлэх.

88а су Ах нар, Ах; Эгч.

б Мат. 18:15–17.

в су Хүлээн

зөвшөөрөх, Хүлээн
зөвшөөрөлт.

90а су Зэмлэх, Зэмлэл.

сүүлчийн хэсэг нь дэлхийн үндэстнүүдэд ахлагч нарын өгөх ёстой сэрэмжлүүлгийг агуулдаг.

1–7, Илчлэлтүүд хийгээд зарлигууд зөвхөн томилогдсон нэгнээр дамжин ирдэг; 8–14, Их Эзэний өмнө бүх цэвэр ариун байдалд үйлдсэнээр Гэгээнтнүүд ариусгагддаг; 15–22, Ахлагч нар наманчлалыг тунхаглаж мөн хүмүүнийг Их Эзэний агуу өдөрт бэлтгэхээр урагш илгээгддэг; 23–28, Их Эзэн өөрийн дуу хоолойгоор мөн байгалийн хүчнүүдээр дамжуулан хүмүүнтэй харьцдаг; 29–35, Мянган жил мөн Сатаныг хүлэх нь ирэх болно.

Ай анхаарагтун, миний сүмийн ахлагч та нар, мөн та нарт миний ярих үгст чих тавигтун.

2 Учрыг болгоогтун, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, миний гараас “зарлигууд хийгээд илчлэлтүүдийг хүлээн авахын тулд та нарт миний томилсон түүгээр дамжуулан та нар миний сүм дэх “хууль болох зарлигийг хүлээн авсан билээ.

3 Мөн үүнийг та нар лавтайяа мэдэгтүн — хэрэв тэр надад “итгэлтэй хэвээр үлдэх аваас, түүнийг авагдах хүртэл зарлигууд мөн илчлэлтүүдийг хүлээн авахын тулд өөр хэн ч та нарт томилогдох нь үгүй болой.

4 Гэвч үнэнээр, үнэнээр, би

та нарт хэлнэ, энэ нь түүгээр дамжихаас бусдаар өөр “хэн ч энэхүү бэлэгт томилогдох нь үгүй бөлгөө; учир нь хэрэв энэ нь түүнээс авагдах аваас түүний оронд өөр нэгнийг томилохоос бусдаар түүнд хүч байхгүй байх болно.

5 Мөн та нар өөрсдийнхөө өмнө ирэх түүний заасан зүйлүүдийг илчлэлтүүд буюу зарлигуудын адилаар бүү хүлээн ав гэдэг нь та нарт хууль байх ёстой;

6 Мөн та нар “мэхлэгдэхгүй байж болохын тулд, та нар тэдгээр нь надаас бус гэдгийг мэдэж болохын тулд би та нарт үүнийг өгч байна.

7 Учир нь үнэнээр би та нарт хэлнэ, миний томилсон түүгээр дамжуулан та нарын хүлээн авсан хийгээд хүлээн авах тэдгээр илчлэлтүүдийг заахын тулд надаар “томилогдсон тэр нь “хаалганд орж, мөн урьд нь та нарт миний хэлсний нэгэн адил томилогдох болно.

8 Мөн эдүгээ, болгоогтун, миний сүмийг хэрхэн авч явах мөн чиглүүлэхийг, миний өгсөн хуулиуд хийгээд зарлигуудын минь тусгай хэсгүүдийн талаар хэрхэн үйлдэхийг та нар мэдэж бо-

43 2а су Бурханы зарлигууд; Илчлэлт.
б С ба Г 42.
3а Иохан 15:4.
4а С ба Г 28:2–3.

6а С ба Г 46:7.
су Заль, Залилах, Залилан.
7а су Томилох, Томилолт.
б Мат. 7:13–14;

2 Ниф. 9:41; 31:9, 17–18;
3 Ниф. 14:13–14;
С ба Г 22:1–4.

лохын тулд та нар хамтдаа цуглах үедээ бие биендээ “зааварлаж мөн сэнхрүүлэх ёстой хэмээх зарлигийг би та нарт өгч байна.

9 Мөн ийн та нар миний сүмийн хуулинд зааварлагдаж, мөн өөрсдийн хүлээн авсан түүгээрээ “ариусгагдах болно, мөн миний өмнө бүх цэвэр ариун байдалд үйлдэхийн тулд та нар өөрсдөдөө үүрэг хүлээх болно —

10 Ийнхүү та нар үүнийг хийхийн хэрээр, та нарын хүлээн авсан хаант улсад алдар суу “нэмэгдэх болно. Та нар үүнийг хийхгүй байхын хэрээр, энэ нь, бүр та нарын хүлээн авсан нь ч ^бавагдах болно.

11 Та нар өөрсдийнхөө дундах “алдсыг цэвэрлэгтүн; миний өмнө өөрсдийгөө ариусга;

12 Мөн хэрэв та нар хаант улсын алдар сууг хүсэх аваас, миний үйлчлэгч Бага Иосеф Смитийг та нар томил, мөн миний өмнө түүнийг итгэлийн залбирлаар “дэмж.

13 Мөн дахин, би та нарт хэлнэ, хэрэв та нар хаант улсын “нууцуудыг хүсэх аваас, түүнийг хоол хүнс мөн хувцас хунараар, мөн түүнд миний

зарлигласан ажлыг гүйцэлдүүлэхэд нь түүнд хэрэгцээтэй аливаа зүйлээр хангаж өг;

14 Мөн хэрэв та нар үүнийг эс хийх аваас би өөрийнхөө өмнө “цэвэр ариун хүмүүсийг өөртөө нөөцөлж болохын тулд, тэрээр өөрийг нь хүлээн авсан тэдэнтэй хамт үлдэх болно.

15 Дахин би хэлж байна, миний томилсон, миний сүмийн ахлагчид та нар анхаарагтун: Та нар заагдахаар бус, харин та нарын гар дээр миний тавьсан тэдгээр зүйлүүдийг миний “Сүнсний хүчээр хүмүүний үрст ^бзаахаар урагш илгээгддэг буюу;

16 Мөн та нар тэнгэрээс “заагддаг байх ёстой. Өөрсдийгөө ^бариусга мөн та нар бүр миний хэлсний адилаар зааж болохын тулд та нар тэнгэрийн хүчээр “хишиг хүртээгдэх болно.

17 Анхаарагтун та нар, учир нь, болгоогтун, Их Эзэний “агуу ^бөдөр ойрхон байна.

18 Учир нь Их Эзэн тэнгэрээс “дуу хоолойгоо илэрхийлэх өдөр ирэх болно; тэнгэр ^бсэгсрэгдэж мөн дэлхий “чичрэх болно, мөн Бурханы “бүрээ чанга хийгээд удтал

8а С ба Г 88:77.

9а су Ариусгал.

10а Алма 12:10.

б Марк 4:25.

11а су Нүгэл.

12а су Сүмийн удирдагчдыг дэмжих.

13а су Бурханы нууцууд.

14а су Цэвэр ариун, Цэвэр ариун

байдал.

15а су Заах, Багш— Сүнсээр заах.

б су Номлолын ажил.

16а су Сүнсний удирдамж, Сүнслэгээр нөлөөлөгдөх.

б су Ариусгал.

в Лук 24:49;

С ба Г 38:32;

95:8–9; 110:8–10.

17а Малах. 4:5;

С ба Г 2:1; 34:6–9.

б С ба Г 29:8.

су Есүс Христийн Хоёр дахь Ирэлт.

18а Иоел 2:11;

С ба Г 133:50.

б Иоел 2:10; 3:16;

С ба Г 45:48.

в С ба Г 88:87.

г С ба Г 29:13; 45:45.

дуугарах болно, мөн нойрсож буй үндэстнүүдэд: Гэгээнтнүүд та нар ^абосож мөн амьдар; би та нарыг дахин дуудтал нүгэлтнүүд та нар ^вүлдэж мөн ^гнойрс хэмээн хэлэх болно.

19 Иймийн тул та нар ёс бусчуудын дунд олдохгүйн тулд бүсээ бүслэгтүн.

20 Дуу хоолойгоо өргө мөн бүү татгалз. Их Эзэний агуу өдөрт өөрсдийгөө бэлтгэцгээ хэмээн хэлж: Үндэстнүүдийг, хөгшин хийгээд залуу аль алиныг нь, боол хийгээд чөлөөт аль алиныг нь наманчлахад дуудагтун;

21 Учир нь хэрэв би хүн байгаад, дуу хоолойгоо өргөн мөн наманчил хэмээн та нарыг дуудах аваас, мөн та нар намайг үзэн ядах аваас — Наманчлагтун, мөн Их Эзэний агуу өдөрт бэлтгэгтүн хэмээн “аянганууд амьдардаг бүхний чихэнд өгүүлэн дуу хоолойгоо дэлхийн хязгааруудаас илэрхийлэх тэрхүү өдөр ирэхэд та нар юу хэлэх сэн билээ?

22 Тийм ээ, мөн дахин, аянгын гялбаа дорноос өрнөд уруу зурсхийн гялбахад, мөн амьд бүхэнд тэдний дуу хоолой урагш илэрхийлэгдэхэд мөн сонсох бүхний чихэнд хангинан — Наманчлагтун та нар, учир нь Их Эзэний агуу

өдөр айсуй хэмээх эдгээр үгсийг хэлэхэд буюу?

23 Мөн дахин, Их Эзэн дуу хоолойгоо тэнгэрээс илэрхийлэн: Анхаарагтун, Ай, дэлхийн үндэстнүүд та нар, мөн та нарыг бий болгосон Бурханы үгийг сонс хэмээн хэлэх ажгуу.

24 Ай, дэлхийн үндэстнүүд та нар, “тахиа дэгдээхийнүүдээ далавчин дороо цуглуулдаг шиг би та нарыг хичнээн ч удаа цуглуулах сан хэмээв, харин та нар ^бхүссэнгүй!

25 Хичнээн удаа би өөрийн “үйлчлэгчдийн амаар, мөн тэнгэр элчүүдийн ^бтохинууллаар мөн өөрийнхөө дуу хоолойгоор, мөн аянгын дуу хоолойгоор, мөн гялбааны дуу хоолойгоор, мөн шуурганы дуу хоолойгоор, мөн газар хөдлөлтийн дуу хоолойгоор, мөн агуу их мөндөрөн шуурга, мөн төрөл бүрийн ^вөлсгөлөн хийгээд өвчин тахлын дуу хоолойгоор, мөн бүрээний агуу дуугаар, мөн шүүлтийн дуу хоолойгоор, мөн өдрийн турш үргэлжлэх ^гнигүүлслийн дуу хоолойгоор, мөн агуу алдар суу мөн хүндэтгэл мөн мөнх амьдралын баялгуудын дуу хоолойгоор та нарыг ^ддуудсан билээ, мөн та нарыг ^еүүрдийн авралд

18д су Амилуулалт.

е С ба Г 76:85;
88:100–101.

ё Морм. 9:13–14.

21а 2 Ниф. 27:2;

С ба Г 88:90.

24а Мат. 23:37;

3 Ниф. 10:4–6.

б су Эсэргүүцэл.

25а Мат. 23:34.

су Бошиглогч.

б С ба Г 7:6; 130:4–5.

в Иер. 24:10; Амос 4:6;

С ба Г 87:6;

ИС—А 1:29.

г су Нигүүлсэнгүй,

Нигүүлсэл.

д Хил. 12:2–4.

е су Мөнх амьдрал;

Мөнх бус, Мөнх бус

байдал; Аврал.

аврахыг хүсэв, гэвч та нар хүссэнгүй!

26 Болгоогтун, миний зэвүүцлийн хилэнгийн аяга дүүрэх тэр өдөр ирчихээд байна.

27 Болгоогтун, эдгээр нь чиний Бурхан Их Эзэний үгс мөн гэдгийг үнэнээр би та нарт хэлж байна.

28 Иймийн тул, хөдөлмөрлөгтүн та нар, сүүлчийн удаа миний талбайд “хөдөлмөрлөгтүн та нар—сүүлчийн удаа дэлхийн оршин суугчдыг дууд.

29 Учир нь би өөрийн тогтоосон цагт шүүлтийн тулд дэлхийд “ирэх болно, мөн миний хүмүүс гэтэлгэгдэх болно мөн дэлхий дээр надтай хамт хаанчлах болно.

30 Учир нь өөрийн үйлчлэгчдийн амаар миний ярьсан агуу “Мянган ирэх болно.

31 Учир нь “Сатан ^бхүлэгдэх болно, мөн тэр дахин сул-

лагдсан үедээ зөвхөн “богинохон хугацаанд хаанчлах болно, мөн тэгээд дэлхийн ‘төгсгөл ирэх бөлгөө.

32 Мөн “зөв шударгаар амьдрах тэр нь нүд ирмэхийн зуур ^бөөрчлөгдөх болно, мөн дэлхий галаар алга болох болно.

33 Мөн ёс бусчууд унтрашгүй “гал уруу хаягдах болно, мөн тэдний төгсгөлийг дэлхий дээр хэн ч мэдэх нь үгүй, мөн миний өмнө тэд ^бшүүлтэнд ирэх хүртэл хэзээ ч мэдэх нь үгүй.

34 Анхаарагтун та нар эдгээр үгсийг. Болгоогтун, Бибээр Есүс Христ, дэлхийн “Аврагч болой. Эдгээр зүйлүүдийг зүрх сэтгэлдээ ^бнөөцөл, мөн үүрд мөнхийн “чанд байдал та нарын ‘оюун ухаанд ^боршиг.

35 “Хэрсүү бай. Миний бүх зарлигуудыг дага. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 44

1831 оны хоёрдугаар сарын сүүлчээр Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон хоёрт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:157). Энд толилуулагдсан шаардлагыг дагахын тулд чуулганыг ирэх зургадугаар сарын эхэнд хийгдэхээр Сүм товлов.

28a Иаков 5:71;

С ба Г 33:3.

су Их Эзэний талбай.

29a су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

30a су Мянган жил.

31a 1 Ниф. 22:26.

су Чөтгөр.

б С ба Г 45:55; 84:100; 88:110.

в Илч. 20:3;

Иаков 5:77;

С ба Г 29:22.

г су Дэлхий—

Дэлхийн төгсгөл.

32a су Зөв шударга,

Зөв шударга ёс.

б 1 Кор. 15:51–52;

С ба Г 63:51; 101:31.

су Амидуулалт.

33a Мат. 3:12.

б су Есүс Христ—

Шүүгч.

34a су Аврагч.

б ИС—А 1:37.

в С ба Г 84:61; 100:7–8.

г су Оюун.

д су Тунгаан бодох.

35a Ром 12:3;

С ба Г 18:21.

1-3, Чуулганд ахлагч нар цугла-
рах ёстой; 4–6, Тэд уг нутгийн
хуулиудын дагуу зохион байгуу-
лах мөн ядуусын төлөө анхаа-
рал халамж тавих ёстой.

БОЛГООГТУН, миний сү-
мийн ахлагчид дорноос
хийгээд өрнөөс мөн умардаас
хийгээд өмнөдөөс захидлаар
буоу зарим өөр замаар дуу-
дагдах ёстой нь миний хувьд
зүйтэй хэмээн Их Эзэн өө-
рийн үйлчлэгчид та нарт
хэлж байна.

2 Мөнхүү улиран тохиох дор,
тэд итгэлтэй байж, мөн надад
итгэх итгэлээ хөгжүүлэхийн
хэрээр, тэд өөрсдийгөө хам-
тад нь цуглуулсан тэр өдөр
бибээр “Сүнсээ тэдний дээр
юүлэх болно.

3 Мөнхүү улиран тохиох дор,
тэд эргэн тойрныхоо бүс нут-
гууд уруу явж, мөн хүмүүст
наманчлалыг “номлох ёстой.

4 Мөн олон нь “хөрвүүлэг-
дэх болно, ингэснээр хүний
хуулийн дагуу өөрсдийгөө
зохион байгуулах хүчийг та
нар олж авах болно;

5 Та нарын “дайснауд та
нарын дээр хүчгүй байж
болохын тулд; та нар бүх
зүйлд хамгаалагдаж боло-
хын тулд; та нар миний хуу-
лиудыг сахих боломжтой
байж болохын тулд; ийнхүү
миний хүмүүсийг устгахыг
эрэлхийлдэг дайсны хүлээс
бүр тасарч болохын тулд
бөлгөө.

6 Болгоогтун, би та нарт
хэлж байна, та нарын хү-
лээн авсан миний хуулиу-
дын дагуу бүх зүйл хийгдэж
болох хүртэл тэд хадгалаг-
даж болохын тулд та нар
ядуус хийгээд гачигдагсдад
“зочлон мөн тэднийг хөн-
гөвчлөхийн тулд туслах ёс-
той. Амен.

ХЭСЭГ 45

1831 оны гуравдугаар сарын 7-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Сүмд өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:158–163). Энэхүү илчлэлтийн цэдгийн оршил болгон Бошиглогч, “Сүмийн энэ үед ажлыг сонирхох, эсвээс итгэлийг тэврэн авахаас хүмүүсийг холдуулахын тулд . . . олон хуурамч илтгэл . . . мөн мунхаг түүхүүд нийтлэгдэж . . . мөн тараагдсан байлаа . . . Гэвч Гэгээнтнүүдийн баяр баясалд, . . . бибээр дараах зүйлийг хүлээн авсан бөлгөө” хэмээн өгүүлжээ (History of the Church, 1:158).

1–5, Христ бол Эцэгийн өмнө
бидний өмгөөлөгч болой; 6–10,
Сайн мэдээ бол Их Эзэний өмнө
замыг бэлтгэх элч бөлгөө; 11–15,

Енох болон түүний ахан дүүс
Их Эзэнээр өөрт нь хүлээн
авагдсан ажгуу; 16–23, Христ
өөрийн ирэлтийн тэмдгүүдийг

44 2a Үйлс 2:17.
3a су Номлох.
4a су Хөрвүүлэг,

Хөрвөгч.
б С ба Г 98:5–7.
5a 2 Ниф. 4:33.

6a Иаков 1:27.
су Өрөвч сэтгэл;
Халамж.

Чидуны Уулан дээр өгсөний адилаар илчлэв; 24–38, Сайн мэдээ сэргээгдэх болно, харийнханы цаг гүйцэлдэх болно, мөн уг нутагт эзгүйрүүлэгч өвчин тархах болно; 39–47, Тэмдгүүд, гайхамигууд, мөн Амилуулалт Хоёр дахь Ирэлтэд тохиох ёстой; 48–53, Христ Чидуны Уулан дээр зогсох болно, мөн иудейчүүд түүний гар мөн хөл дэх шархнуудыг харах болно; 54–59, Их Эзэн Мянганы турш хаанчлах болно; 60–62, Бошиглогч Шинэ Гэрээний орчуулгыг эхлэхэд зааварлагдав, үүгээр дамжин чухал мэдээлэл мэдүүлэгдэх болно; 63–75, Цугларахаар мөн бүх үндэстнүүдээс хүмүүс түүн уруу ирэх Шинэ Иерусалимыг барихаар Гэгээнтнүүд зарлиг болгогдов.

АНХААРАГТУН, Ай “хаант Аулс өгөгдсөн миний ⁶сүмийн хүмүүс та нар; дэлхийн суурийг тавьсан, тэнгэрийг мөн үүний бүх олныг бүтээсэн, мөн аж төрдөг, мөн хөдөлдөг, мөн амьдардаг бүх зүйл түүгээр ⁶бүтээгдсэн түүнийг та нар анхааран сонсож мөн түүнд чих тавигтун.

2 Мөн дахин би хэлж байна, та нарын бодоогүй ^ацагт зун улиран одож, мөн ^бургац хураалт өнгөрч, мөн та нарын

сүнс аврагдаагүй байхад “үхэл та нар дээр ирэхгүйн тулд миний дуу хоолойг анхаарагтун;

3 Эцэгийн өмнө “өмгөөлөгч болох намайг, түүний өмнө та нарын өмнөөс гуйх намайг анхааран сонсогтун —

4 Өгүүлрүүн: Эцэг минь, “нүгэл үйлдээгүй, таны таалалд нийцсэн түүний ⁶зовлон хийгээд үхлийг болгоогтун; мөн Хүүгийнхээ асгарсан цусыг, мөн та өөрөө ^аалдаршихын тулд таны өгсөн, бас түүний цусыг болгоогтун;

5 Иймийн тул, Эцэг минь, тэд надад ирж бас “мөнх амьдралыг авч болохын тулд миний нэрэнд ^битгэх эдгээр ах дүүсийг минь өршөөгөөч.

6 Анхаарагтун, Ай миний сүмийн хүмүүс та нар, мөн ахлагчид та нар хамтдаа анхааран сонсогтун, мөн “өнөөдөр хэмээн нэрлэгдэж байхад дуу хоолойг минь анхааран сонсогтун, мөн зүрх сэтгэлээ бүү хатууруулагтун;

7 Учир нь би бол “Альфа ба Омега, эхлэл ба төгсгөл, дэлхийн гэрэл ба амьдрал — харанхуйд гялалзагч ⁶гэрэл бөгөөд мөн харанхуй нь түүнийг ойлгох нь үгүй гэдгийг би та нарт үнэнээр хэлнэ.

45 1а С ба Г 50:35.

б су Есүс Христийн Сүм.

в Иер. 14:22;

3 Ниф. 9:15;

С ба Г 14:9.

су Бүтээх, Бүтээл.

2а Мат. 24:44.

б Иер. 8:20;

С ба Г 56:16.

су Ургац хураалт.

в Алма 34:33–35.

3а С ба Г 62:1.

су Өмгөөлөгч.

4а Евр. 4:15.

б С ба Г 19:18–19.

су Цагаатгах,

Цагаатгал.

в Иохан 12:28.

5а Иохан 3:16.

б С ба Г 20:25;

35:2; 38:4.

6а Евр. 3:13;

С ба Г 64:23–25.

7а Илч. 1:8; 21:6;

С ба Г 19:1.

б Иохан 1:5.

8 Би өөрийнхөндөө ирсэн бөгөөд өөрийнхөн маань намайг хүлээн авсангүй; гэвч намайг хүлээн авсан болгонд олон “гайхамшигийг үйлдэх мөн Бурханы ^бхөвгүүд болох ^вхүчийг өгсөн би; мөн бүр миний нэрэнд ^гитгэх тэдэнд ^дмөнх амьдралыг олж авах хүчийг өгсөн бөлгөө би.

9 Мөн бүр ийн, дэлхийд гэрэл байхын төлөө, мөн миний хүмүүсийн хувьд “жишиг байхын тулд, мөн ^бхарийнханы хувьд үүнийг эрэлхийлэхийн тулд, мөн миний өмнө замыг бэлтгэхэд нүүрний минь өмнө ^вэлч байхын тулд, өөрийн ^гмөнхийн ^дгэрээг дэлхийд илгээсэн бөлгөө би.

10 Иймийн тулд, үүнд ирэгтүн та нар, мөн ирэх түүнтэй бибээр эрт дээр үеийн хүмүүсийн адилаар хэлэлцэх болно, мөн та нарт өөрийн “хүчирхэг хэлэлцүүлгийг үзүүлэх болно би.

11 Иймийн тулд, хамтдаа анхаарагтун та нар, мөн “Енох болон түүний ах нарын Бурхан хэмээн та нарын хэлэх, бүр өөрийн мэргэн ухааныг та нарт үзүүлбэ би,

12 Бүх ариун хүмүүсээр эрэлхийлэгдэж байсан тэр өдөр — зөв шударгын тэрхүү өдөр ирэх хүртэл дэлхийгээс “тусгаарлагдсан тэд — тэрхүү ^бхот хадгалагдан үлдэж, надад өөрт минь хүлээн авагдсан буюу, мөн ёс бус явдал хийгээд жигшүүрт хэргүүдийн улмаас тэд үүнийг олоогүй бөлгөө;

13 Мөн гэмээ хүлээсэн тэд бол дэлхий дээрх “харь хүмүүс хийгээд эрэн хайгчид байлаа;

14 Харин тэд үүнийг олж мөн өөрсдийн бие махбодид үүнийг үзэх болно гэсэн “амлалт хүлээн авсан юм.

15 Иймийн тул, анхаарагтун мөн бибээр та нартай эрт дээр үеийн хүмүүсийн адилаар хэлэлцэж, мөн бибээр та нарт ярьж мөн бошиглох авай.

16 Мөн бибээр мах бодиороо тэдний өмнө зогсож байхдаа: Та нарын эцгүүдэд өгсөн амлалтуудаа гүйцэлдүүлэхийн тулд тэнгэрийн үүлэнд алдар суундаа бибээр ирэх тэр өдөр дэх миний ирэлтийн “тэмдгүүдийн талаар та нар надаас асуусны учир хэмээн хэлж, үүнийг шавь нартаа ^бүзүүлс-

8а су Гайхамшиг.

б су Бурханы

хөвгүүд охид.

в Мат. 10:1.

сү Хүч.

г су Итгэлтэй байх,

Итгэл; Итгэл.

д С ба Г 14:7.

9а 2 Ниф. 29:2.

б Иса. 42:6;

2 Ниф. 10:9–18.

в Малах. 3:1.

г су Шинэ бөгөөд

үүрдийн гэрээ.

д Иер. 31:31–34;

Морм. 5:20.

10а Иса. 41:21;

С ба Г 50:10–12.

11а Моце 7:69.

12а исо, Эхл. 14:30–34;

С ба Г 38:4;

Моце 7:21.

б Моце 7:62–64.

су Сион.

13а Евр. 11:13;

1 Петр 2:11.

14а Евр. 11:8–13;

Моце 7:63.

16а су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

б Мат. 24;

Лук 21:7–36;

ИС—А 1.

ний адилаар мөн үүнийг тодорхойгоор үзүүлэх болно би.

17 Учир нь та нарын ^асүнснүүд бие махбодиос тань урт удаан хугацаанд ^бсалсныг боолчлол хэмээн та нар үзэж байсны учир, гэтэлгэлийн өдөр хэрхэн ирэхийг, мөн тэрчлэн ^втараагдсан Израилын ^гсэргээлтийг та нарт үзүүлэх болно би.

18 Мөн эдүгээ та нар Бурханы өргөө хэмээн та нарын нэрлэх, Иерусалим дахь энэ ариун сүмийг болгоогтун, мөн дайснууд чинь энэ өргөө хэзээ ч унахгүй хэмээн хэлэх болно.

19 Гэвч, энэ үеийнхэн дээр сүйрэл шөнийн хулгайч адил ирэх болно, мөн энэ хүмүүс устгагдаж мөн бүх үндэстнүүдийн дунд тараагдах болно гэдгийг үнэнээр та нарт хэлнэ би.

20 Мөн нэг чулуу нөгөө дээрээ үлдэхгүйн тулд та нарын эдүгээ харж буй энэ ариун сүм доош хаягдах болно.

21 Мөнхүү улиран тохиох дор, тэдний талаар та нарт миний ярьсан аливаа эзгүйрэл улиран тохиох хүртэл иудейчүүдийн энэ үеийнхэн алга болох нь үгүй.

22 Дэлхийн ^атөгсгөл ирнэ гэдгийг та нар мэднэ хэмээн

та нар хэлдэг; тэнгэр хийгээд дэлхий алга болно гэдгийг та нар мэднэ хэмээн тэрчлэн та нар хэлдэг;

23 Мөн үүн дээр та нар үнэнээр хэлдэг авай, учир нь энэ нь ийм буюу; гэвч бүгд гүйцэлдэх хүртэл та нарт миний ярьсан эдгээр зүйлүүд алга болох нь үгүй.

24 Мөн Иерусалимын талаар үүнийг та нарт хэллээ би; мөн тэр өдөр ирэхэд, үлдэгсэд нь бүх үндэстнүүдийн дунд ^атараагдах болно;

25 Гэвч тэд дахин ^ацуглуулагдах болно; гэхдээ ^бхарийнханы цаг гүйцэлдэх хүртэл тэд үлдэх болно.

26 Мөн ^атэр өдөр ^бдайнууд хийгээд дайнуудын цуурхал сонсогдох болно, мөн бүхэл дэлхий үймээн самуунд байх болно, мөн хүмүүний зүрх сэтгэл ^вмохох болно, мөн дэлхийн төгсгөлийг хүртэл Христ өөрийн ирэлтийг ^гхойшлуулна хэмээн тэд хэлэх болно.

27 Мөн хүмүүний хайр хөрч, мөн алдас газар авах болно.

28 Мөн ^аХарийнханы цаг ирэхэд, харанхуйд суугч тэдний дунд ^бгэрэл гийх болно, мөн энэ нь миний сайн мэдээний бүрэн байдал байх болно;

17а су Сүнс.
б С ба Г 138:50.
в 1 Ниф. 10:12–14.
су Израил—
Израилын
тараагдалг.
г су Израил—
Израилын
цугларалт.

22а су Дэлхий—
Дэлхийн төгсгөл.
24а 2 Ниф. 25:15.
25а Нех. 1:9; Иса.
11:12–14;
1 Ниф. 22:10–12;
2 Ниф. 21:12–14.
б Лук 21:24.
26а су Эцсийн өдрүүд,

Хожмын өдрүүд.
б С ба Г 87;
ИС—А 1:23.
в Лук 21:26.
г 2 Петр 3:3–10.
28а 1 Ниф. 15:13.
б су Гэрэл, Христийн
гэрэл; Сайн
мэдээний сэргээлт.

29 Гэвч тэд үүнийг “хүлээн авах нь үгүй; учир нь тэд гэрлийг хүртэх нь үгүй, мөн хүмүүний ^бдүрмүүдийн улмаас тэд “зүрх сэтгэлээ надаас буруулдаг.

30 Мөн тэр үед харийнханы цаг гүйцэлдэх болно.

31 Мөн давшгүй их “цээрлүүлэлтийг үзэх хүртлээ, үхэхгүй хүмүүс тэр үед амьдарсаар байх болно; учир нь эзгүйрүүлэгч өвчин уг нутгийг бүрхэх болно.

32 Гэвч миний шавь нар ариун газруудад “амьдарсаар байх болно, мөн шилжин нүүлгэгдэх нь үгүй бөлгөө; харин ёс бусчуудын дундах хүмүүс дуу хоолойгоо өргөж тэгээд Бурханыг ^бзүхэн мөн үхэх болно.

33 Мөн тэрчлэн энд тэндгүй “газар хөдлөлтүүд, мөн үй олон эзгүйрэл байх болно; гэсэн хэдий ч хүмүүн миний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулсаар байх болно, мөн бие биенийхээ эсрэг тэд ^билд агсан, мөн тэд бие биенээ хөнөөх болно.

34 Мөн эдүгээ, Их Эзэн бибээр эдгээр үгсийг шавь нартаа ярихад тэд тэвдэн сандарсан бөлгөө.

35 Мөн бибээр тэдэнд

хэлэв: Бүү тэвдэн “сандар, учир нь, мөн эдгээр бүх зүйл тохиоход та нарт өгөгдсөн тэрхүү амлалтууд биелэгдэх болно гэдгийг та нар мэдэж болно.

36 Мөн гэрэл гийж эхлэхэд, энэ нь тэдний хувьд та нарт миний үзүүлэх тэрхүү сургаалт зүйрлэл лугаа адил байх болно—

37 Та нар “инжир моднуудыг үзэж мөн болгоогтун, мөн та нар нүдээрээ тэдгээрийг үзэх авай, тэдгээрийн нахиалж эхлэхийг, мөн тэдгээрийн навчис нь нялхаараа байгааг хараад зун ойрхон байна хэмээн та нар хэлдэг;

38 Тэд эдгээр бүх зүйлийг харах тэрхүү өдөр энэ нь бүрийм байх болно, тэгээд тэр цаг ойрхон байгааг тэд мэдэх болно.

39 Мөнхүү улиран тохиох дор, надаас “эмээдэг тэрээр Их Эзэний агуу ^бөдөр ирэхийг, бүр ^бХүний Хүүгийн ирэлтийн ^гтэмдгүүдийг ^дхүсэн хүлээсээр байх болно.

40 Мөн тэмдгүүд болон гайхамшгуудыг тэд үзэх болно, учир нь дээр тэнгэрт, мөн доор дэлхийд тэдгээр нь үзүүлэгдэх болно.

29a Иохан 1:5.

б С ба Г 3:6–8; 46:7;

ИС—Т 1:19.

в Мат. 15:8–9.

31a С ба Г 5:19–20;

97:22–25.

32a С ба Г 101:21–22, 64.

б Илч. 16:11, 21.

33a С ба Г 43:18;

88:87–90.

б С ба Г 63:33.

35a Мат. 24:6.

37a Марк 13:28;

Лук 21:29–31.

39a С ба Г 10:55–56.

сү Айх, эмээх—

Бурханаас эмээх;

Дуулгавартай байх,

Дуулгавартай,

Дуулгавартай

дагах.

б сү Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

в сү Хүний Хүү.

г сү Цаг хугацааны

тэмдгүүд.

д 2 Петр 3:10–13;

С ба Г 35:15–16;

Моце 7:62.

41 Мөн цус, мөн “гал, мөн суунаглах утааг тэд болгоох болно.

42 Мөн Их Эзэн ирэх тэр өдрийн өмнө, “нар харанхуйлж, мөн сар цус болон хувирч бас однууд тэнгэрээс унах болно.

43 Мөн үлдэгсэд нь энэ газарт цуглуулагдах болно;

44 Мөн тэгээд тэд намайг эрэх болно, мөн, болгоогтун, бибээр ирэх болно; мөн тэд намайг тэнгэрийн үүлэн дотор сүр хүч хийгээд агуу “алдар суунд, бүх ариун тэнгэр элчүүдийн хамт үзэх болно; мөн намайг эс “эрэлхийлэх тэрээр тусгаарлагдах болно.

45 Гэвч Их Эзэний мутар буухын өмнө, тэнгэр элч “бүрээгээ үлээж, мөн нойрссон гэгээнтнүүд “үүлэн дунд намайг угтахгаар “урагш гарч ирэх болно.

46 Иймийн тул, хэрэв та нар “амар амгаланд нойрссон аваас адислагдсан болой та нар; учир нь та нар эдүгээ намайг болгоодог мөн би байдгийг мэддэг учраас, бүр та нар тийн над уруу “ирэх болно мөн та нарын сүнс “амьдрах болно, та нарын гэтэлгэл төгөлдөржих болно; мөн гэгээнтнүүд дэлхийн дөрвөн зүгээс урагш гарч ирэх болно.

47 Тэгээд Их Эзэний “мутар үндэстнүүд дээр буух болно.

48 Мөн тэгээд Их Эзэн хөлөө энэ “уулан дээр тавих болно, мөн энэ нь хоёр хэсэг хуваагдах болно, бас газар “чичрэн, мөн нааш цааш ганхах болно, бас тэнгэр тэрчлэн сэгсрэгдэх “болно.

49 Мөн Их Эзэн дуу хоолойгоо илэрхийлэх болно, мөн дэлхийн бүх хязгаарууд үүнийг сонсох болно; бас дэлхийн үндэстнүүд эмгэнэн “гашуудах болно, мөн шоолох тэд өөрсдийнхөө мунхгийг харах болно.

50 Мөн сүйрэл шоологчийг нөмрөх болно, мөн элэглэгч нь үрэгдэх болно; мөн алдсыг эрэлхийлсэн тэдгээр нь тас цавчигдан мөн галд хаягдах болно.

51 Мөн тэгээд “иудейчүүд намайг “харж мөн: Таны гар мөн хөл дээрх эдгээр шархнууд чинь юу вэ? хэмээн хэлэх болно.

52 Тэгээд бибээр Их Эзэн гэдгийг тэд мэдэх болно; учир нь: Эдгээр шархнууд бол найз нарынхаа гэрт миний “шархадсан тэрхүү шархнууд болой. Бибээр дээш өргөгдсөн тэрбээр болой. Би бол “цовдлогдсон Есүс болой.

41a С ба Г 29:21;
97:25–26.

42a Иоел 2:10;
Илч. 6:12;
С ба Г 88:87; 133:49.

44a су Есүс Христ—
Есүс Христийн
алдар суу.
б Мат. 24:43–51;

Марк 13:32–37.
45a С ба Г 29:13; 43:18.

б 1 Тес. 4:16–17.
в С ба Г 88:96–97.
су Амилуулалт.

46a Алма 40:12.
б Иса. 55:3.
в су Мөнх амьдрал.
47a С ба Г 1:12–16.

48a Зех. 14:4.
б С ба Г 43:18; 88:87.

в Иоел 3:16;
С ба Г 49:23.

49a С ба Г 87:6.
51a су Иудейчүүд.
б Зех. 12:10.

52a Зех. 13:6.
б су Цовдлуулалт.

Би бол Бурханы Хүү хэмээн би тэдэнд хэлэх болно.

53 Мөн тэгээд тэд алдсуудынхаа учир цурхиран “уйлах болно; тэгээд тэд ^бхаанаа мөрдөн хавчсаны улмаас тэд гүнээ эмгэнэн гашуудах болно.

54 Мөн тэгээд “Бурханыг мэддэггүй үндэстнүүд гэтэлгэгдэх болно, мөн хуулийг мэддэггүй байсан тэд анхны ^бамилуулалтад багтах болно; мөн энэ нь тэдний хувьд ^бтэвчиж болохуйц байх болно.

55 Мөн “Сатан хүмүүний үрсийн зүрх сэтгэлд байргүй байхын тулд ^бхүлэгдэх болно.

56 Мөн намайг алдар суундаа залран ирэх тэр “өдөр арван ^бонгон охины талаар миний ярьсан сургаалт зүйрлэл хэрэгжих болно.

57 Учир нь мэргэн хийгээд “үнэнийг хүлээн авсан, мөн Ариун Сүнийг ^бзам заагчаа болгон авсан, мөн ^бмэхлэгдээгүй тэд — үнэнээр би та нарт хэлнэ, тэд тас цавчигдан мөн ‘галд хаягдахгүй, харин тэр өдрийг тэсэн гарах болно.

58 Мөн “дэлхий тэдэнд ^бөв болон өгөгдөх болно; мөн тэд өсөн үржиж мөн хүчтэй болох болно, мөн тэдний үр

хүүхдүүд нүгэлгүйгээр “авралд ^бөсөн өндийх болно.

59 Учир нь Их Эзэн тэдний “дунд байх болно, мөн түүний алдар суу тэдний дээр байх болно, мөн тэрбээр тэдний хаан хийгээд тэдний ^бхууль тогтоогч байх болно.

60 Мөн эдүгээ, болгоогтун, би та нарт хэлнэ, “Шинэ Гэрээ орчуулагдах хүртэл энэ бүлгийн талаар цаашид аливааг мэдэх нь та нарт өгөгдөхгүй байх болно, мөн үүнд эдгээр бүх зүйл мэдүүлэгдэх болно;

61 Иймийн тул, ирэх ёстой тэр зүйлүүдэд чи бэлтгэгдэж болохын тулд чи үүнийг эдүгээ орчуулж болно гэдгийг би чамд зөвшөөрч байна.

62 Учир нь агуу зүйлүүд та нарыг хүлээж байна гэдгийг үнэнээр би та нарт хэлнэ;

63 Та нар харийн нутгууд дахь “дайнүүдын тухай сонсдог; гэвч, болгоогтун, би та нарт хэлнэ, тэдгээр нь ойрхон бүр та нарын хаалган дээр байна, мөн энэ үеэс хойш олон жил бололгүй өөрийн нутгууд дахь дайнүүдын тухай та нар сонсох болно.

64 Иймийн тул та нар

53a Илч. 1:7;
 б Лук 23:38;
 Иохан 19:3, 14–15.
 54a Езек. 36:23; 39:21.
 б су Амилуулалт.
 в С ба Г 75:22.
 55a су Чөтгөр.
 б Илч. 20:2;
 1 Ниф. 22:26;
 С ба Г 43:31; 88:110.
 56a су Есүс Христийн
 Хоёр дахь Ирэлт.

б Мат. 25:1–13;
 С ба Г 63:54.
 57a су Үнэн.
 б су Ариун Сүнс.
 в ИС—А 1:37.
 з С ба Г 29:7–9; 63:34;
 64:23–24; 101:22–25.
 58a су Мянган жил.
 б Мат. 5:5.
 в су Аврал.
 з С ба Г 63:51;
 101:29–31.

59a С ба Г 29:11; 104:59.
 б Эхл. 49:10;
 Зех. 14:9;
 С ба Г 38:21–22.
 60a су Иосеф Смитийн
 Орчуулга (ИСО).
 Иосеф Смитийн
 Библийн орчуулгаас
 сонгож авсан хэсгийг мөн үз.
 63a С ба Г 38:29; 87:1–5;
 130:12.

“дорнын нутгуудаас цуглар, миний сүмийн ахлагчид та нар өөрсдийгөө нэгтгэн цуглуулагтун гэдгийг Их Эзэн, бибээр хэлсэн билээ; та нар өрнөд нутгууд уруу яв, оршин суугчдыг наманчлалд дуудагтун, мөн тэд наманчлахын хэрээр сүмүүдийг надад өсгөн бэхжүүлэгтүн.

65 Мөн та нар үүнээс хойш өөрсдөд чинь ноогдох өвийг “худалдан авч болохын тулд, нэг зүрх сэтгэлтэйгээр, мөн нэг оюунтайгаар баялгуудаа нэгтгэгтүн.

66 Мөн энэ нь “Шинэ Иерусалим, ⁶амар амгалангийн ⁶нутаг, ⁷хоргодох хот, Хамгийн Дээд Бурханы гэгээнтнүүдийн аюулгүй байдлын газар хэмээн нэрлэгдэх болно;

67 Мөн тэнд Их Эзэний “алдар суу байх болно, мөн Их Эзэнээс эмээх айдас тэрчлэн тэнд байх болно, ёс бусчууд үүнд ирэхгүй байхын хэрээр энэ нь Сион хэмээн нэрлэгдэх болно.

68 Мөнхүү улиран тохиох дор ёс бусчуудын дунд хөршийнхөө эсрэг илдээ үл агсах хүн бүр аюулгүй байдлын тулд Сионд зугтан очих ёстой нь шаардлагатай болой.

69 Мөн тэнгэрийн доорх үндэстэн бүрээс үүнд “цуглуулагдах болно; мөн энэ нь бие

биентэйгээ эс дайтах цорын ганц хүмүүс байх болно.

70 Мөн ёс бусчуудын дунд: Сионы эсрэг тулалдахаар явахгүй байцгаая, учир нь Сионы оршин суугчид аймшигтай болой, иймийн тул бид цэх зогсож чадахгүй хэмээн яригдах болно.

71 Мөнхүү улиран тохиох дор бүх үндэстнүүдийн дундаас зөв шударгыг үйлдэгчид цуглуулагдах болно, мөн үүрдийн баяр баясгалангийн дууг дуулан Сионд ирэх болно.

72 Мөн эдүгээ та нар энэ ажлыг хүмүүсийн нүдэн дээр, мөн дайснуудынхаа нүдэн дээр хэрэгжүүлж болохын тулд, өөрсөд тань миний зарлигласан тэр зүйлийг та нар гүйцэлдүүлэх хүртэл тэд та нарын ажлуудыг мэдэхгүй байж болохын тулд, энэ нь надад зүйтэй болтол эдгээр зүйлүүдийг дэлхийд таран одохоос хамгаалагтун гэдгийг би та нарт хэлнэ;

73 Тэд үүнийг мэдэх үедээ тэд эдгээр зүйлүүдийг тунгаан бодож болохын тулд буюу.

74 Учир нь Их Эзэн заларч ирэх үед, тэд “айдаст баригдсаны улмаас, тэрээр тэдэнд аймшигтай байх болно, мөн тэд хол байж мөн дагжин чичрэх болно.

75 Мөн бүх үндэстнүүд Их

64a С ба Г 42:64.

65a С ба Г 63:27.

66a Ифер 13:5–6;

Моце 7:62;

ИТ 1:10.

су Шинэ

Иерусалим; Сион.

б су Амар амгалан.

в С ба Г 57:1–3.

г Иса. 4:6;

С ба Г 115:6.

67a С ба Г 64:41–43;

97:15–18.

су Есүс Христ—

Есүс Христийн алдар суу.

69a Дэд хууль 30:3;

Иер. 32:37–39;

С ба Г 33:6.

74a Зеф. 2:11.

Эзэнээс эмээх айдас, мөн түүний хүч чадлын сүр хүчний

улмаас айн ширвээтэх болно. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 46

1831 оны гуравдугаар сарын 8-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:163–165). Сүмийн энэ эхний үед, Сүмийн үйлчлэлийг хөтлөн явуулах нэгдмэл загвар тогтож амжаагүй байлаа. Хэдий тийм ч, ариун ёслолын цуглаанууд хийгээд Сүмийн бусад цугларалтуудад зөвхөн гишүүд хийгээд чин үнэнч сонирхогчдыг оруулдаг заншил ямар нэг хэмжээгээр нийтлэг болоод байв. Энэхүү илчлэлт цуглаануудыг хянах болон хөтлөн явуулахтай холбоотой Их Эзэний тааллыг илэрхийлдэг.

1–2, Ариун Сүнсээр хөтлүүлсний дагуу ахлагч нар цуглаануудыг хөтлөн явуулах ёстой; 3–6, Үнэнийг эрэлхийлэгчид ариун ёслолын үйлчлэлээс гадуурхагдах ёсгүй; 7–12, Бурханаас асуу мөн Сүнсний бэлгүүдийг эрэлхийл; 13–26, Эдгээр бэлгүүдээс заримынх нь жагсаалт өгөгдөв; 27–33, Сүнсний бэлгүүдийг ялган таних хүч Сүмийн удирдагчдад өгөгддөг.

АНХААРАГТУН, Ай миний Сүмийн хүмүүс; учир нь та нарт ярьсан эдгээр зүйлүүд та нарын “ашиг тусын тулд хийгээд сурахад чинь зориулагдсаныг үнэнээр би та нарт хэлж байна.

2 Гэхдээ бичигдсэн тэдгээр зүйлүүд байгаа хэдий ч, бүх цуглаануудыг Ариун Сүнсээр удирдагдан мөн хөтлөгдсөний дагуу “хөтлөн явуулах

нь эхлэлээс миний сүмийн ахлагч нарт өгөгдсөөр ирсэн бөгөөд мөн ямагт тийм байх болно.

3 Гэсэн хэдий ч дэлхийн өмнө явагдах нийтийн цуглаануудаасаа хэн нэгнийг хэзээ ч “зайлуулах ёсгүй нь та нарт зарлиглагдсан бөлгөө.

4 “Сүмд харьяалагдах хэн нэгнийг ариун ёслолын цуглаанаасаа зайлуулах ёсгүй нь та нарт мөн зарлиглагдсан буюу; хэдий тийм ч, хэрэв хэн нэгэн нүгэл үйлдвээс тэрээр дахин засрах хүртлээ ариун ёслолоос бүү хүртэг.

5 Мөн дахин би та нарт хэлж байна, хаант улсыг хичээнгүйлэн эрэлхийлэгч хэнийг ч та нар ариун ёслолоосоо зайлуулах ёсгүй — бибээр үүнийг сүмийн бус хүмүүсийн талаар ярьж байна.

6 Мөн дахин би та нарт хэл-

46 1a 2 Тим. 3:16–17.
2a Моро. 6:9;
С ба Г 20:45.
б Алма 6:1.

3a 3 Ниф. 18:22–25.
су Нөхөрлөл.
4a су Есүс Христийн
Сүм.

б 3 Ниф. 18:26–32.
су Ариун ёслол.

нэ, “гишүүнээр батлах та нарын цуглааны талаар, хэрэв хэн нэгэн нь сүмийнх бус атлаа, хаант улсыг хичээнгүйлэн эрэлхийлэгч байх аваас, та нар тэднийг бүү зайлуул.

7 Гэвч, бүх зүйл дээр өгөөмрөөр өгөгч, Бурханаас “асуух нь та нарт зарлиглагдсан болой; мөн Сүнс чамд гэрчилдэг зүйлийг бүр түүнчлэн чи миний өмнө цэх шулуунаар алхлан, та нар муу ёрын сүнснүүдээр эсвээс, ^бчөтгөрийн сургаалуудаар, эсвээс хүмүүний “зарлигуудаар ‘уруу та тагдахгүйн тулд авралынхаа үр дүнг ^аэргэцүүлэн бодож, бүх зүйлийг залбирал ба “талархалтайгаар хийж, зүрх сэтгэлийнхээ бүхий л ^вцэвэр ариун байдалд үйлдэх ёстой хэмээнэ би; учир нь зарим нь хүмүүнийх, мөн бусад нь чөтгөрийнх байдаг.

8 Иймийн тул, та нар мэхлэгдэхгүйн тулд болгоомжил; мөн та нар мэхлэгдэхгүйн тулд юуны төлөө тэдгээр нь өгөгдсөнийг ямагт санан хамгийн шилдэг бэлгүүдийг хичээнгүйлэн “эрэлхийл;

9 Учир нь үнэнээр би та нарт хэлж байна, эрэлхийлдэг, эсвээс надаас асуудаг, мөн тэд үүнийг шуналт хүс-

лээрээ “үрчихэж болох тэрхүү ^бтэмдгийн төлөө бус асуудаг тэд бүгд ашиг тусыг олж болохын тулд тэдгээр нь намайг хайрладаг хийгээд миний бүх зарлигийг сахьдаг мөн түүнчлэн үйлдэхийг эрэлхийлдэг тэдний ашиг тусын төлөө өгөгддөг болой;

10 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, та нар сүмд өгөгдсөн тэдгээр “бэлгүүд нь юу болохыг ямагт санаж, мөн ^боюундаа ямагт хадгалаасай хэмээнэ би.

11 Учир нь бүгдэд бэлэг бүхэн өгөгддөггүй; учир нь олон бэлэг байдаг, мөн хүн “болгонд Бурханы Сүнсээр бэлэг өгөгддөг болой.

12 Үүгээр бүгд ашиг тусыг олж болохын тулд заримд нь нэг бэлэг өгөгдсөн байдаг, мөн заримд нь өөр бэлэг өгөгддөг болой.

13 Есүс Христ бол Бурханы Хүү, мөн тэрээр дэлхийн нүглүүдийн төлөө цовдлогдсон гэдгийг “мэдэх нь заримд нь Ариун Сүнсээр өгөгддөг болой.

14 Бусдад нь, хэрэв тэд итгэлтэй хэвээр байх аваас тэд түүнчлэн мөнх амьдралтай байж болохын тулд тэдний үгст “итгэх нь өгөгддөг болой.

6а ө.х. Саяхан баптисм хүртэгчдийн гишүүний баталгаа.

7а Иаков 1:5–6;

С ба Г 88:63.

б су Чөтгөр.

в С ба Г 3:6–7; 45:29.

г 1 Тим. 4:1–4;

С ба Г 43:5–7.

д су Тунгаан бодох.

е Дуул. 100;

Алма 34:38.

су Талархалтай,

Талархах, Талархал өргөх.

ё су Ариун байдал.

8а 1 Кор. 12:31.

9а Иаков 4:3.

б су Тэмдэг.

10а 1 Кор. 14:12.

су Сүнсний

бэлгүүд.

б су Оюун.

11а 1 Кор. 12:4–11.

13а су Гэрчлэл.

14а 3 Ниф. 12:2.

су Итгэлтэй байх,

Итгэл.

15 Мөн дахин, заримд нь, Их Эзэний хүссэний дагуу энэ нь мөнхүү Их Эзэний таалалд нийцсэн байхаар, хүмүүний үрсийн нөхцөл байдлуудын дагуу түүний нигүүлсэлд нийцүүлэн, үйлчлэлийн “ялгаануудыг мэдэх нь Ариун Сүнсээр өгөгддөг болой.

16 Мөн дахин, түүгээр ашиг тусыг олохын тулд Сүнсний илэрхийллүүд хүн болгонд өгөгдөж болохын тулд үйл ажиллагааны олон янз байдлыг, эдгээр нь Бурханаас байна уу гэдгийг мэдэх нь заримд нь Ариун Сүнсээр өгөгддөг болой.

17 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлнэ, заримд нь “мэргэн ухааны үг Бурханы Сүнсээр өгөгддөг болой.

18 Мэргэн байх мөн мэдлэгтэй байх нь бүгдэд заагдахын тулд нөгөөд нь “мэдлэгийн үг өгөгддөг болой.

19 Мөн дахин, эдгэрэх “итгэлтэй байх нь заримд нь өгөгддөг болой;

20 Мөн “эдгээх итгэлтэй байх нь бусдад нь өгөгддөг болой.

21 Мөн дахин, “гайхамшгуудыг үйлдэх нь заримд нь өгөгддөг болой;

22 Мөн “бошиглох нь бусдад нь өгөгддөг болой;

23 Мөн сүнснүүдийг “ялган

таних нь заримд нь өгөгддөг болой.

24 Мөн дахин, “хэлнүүдээр ярих нь заримд нь өгөгддөг болой;

25 Мөн хэлнүүдийн хөрвүүлэг нь өөр нэгэнд нь өгөгддөг болой.

26 Мөн эдгээр бүх “бэлгүүд Бурханы “хүүхдүүдийн ашиг тусын тулд, Бурханаас ирдэг болой.

27 Мөн сүмийн “бишопт, мөн Сүмийг харж хандахаар Бурханы тохоон мөн томилох, мөн сүмд ахлагчид байх иймүүдэд нь та нарын дундах Бурханаас хэмээн хэлэх боловч тийм биш байх хэн нэгэн та нарын дунд байхгүйн тулд тэдгээр бүх бэлгийг “ялган таних нь тэдэнд өгөгдөх ёстой.

28 Мөнхүү улиран тохиох дор “Сүнсээр асуудаг тэрээр Сүнсээр хүлээн авах болно;

29 Гишүүн болгон үүгээр ашиг тусыг олж болохын тулд, тэргүүн байхын тулд эдгээр бүх бэлгүүдтэй байх нь заримд нь өгөгдөж болох буюу.

30 “Сүнсээр “асуудаг тэрээр Бурханы “тааллын дагуу асуудаг авай; иймийн тул, энэ нь бүр түүний асуусанчлан үйлдэгддэг болой.

15a Моро. 10:8.

17a Моро. 10:9.

су Мэргэн ухаан.

18a су Мэдлэг.

19a С ба Г 42:48–52.

су Итгэл.

20a су Эдгээх, Эдгэрэх.

21a су Гайхамшиг.

22a су Бошиглох,

Бошиглол.

23a Мосе 1:13–15.

24a су Хэлний бэлгүүд.

26a Моро. 10:8–19.

б су Бурханы

хөвгүүд охид.

27a су Бишоп.

б су Ялган таних

бэлэг.

28a С ба Г 88:64–65.

30a су Ариун Сүнс.

б С ба Г 50:29.

в 2 Ниф. 4:35.

31 Мөн дахин, би та нарт хэлнэ, та нар Сүнсэнд юу ч хийлээ гэсэн, бүх зүйл Христийн нэрэнд үйлдэгддэг байх ёстой;

32 Мөн та нар аливаа адислаалаар адислагдсаныхаа төлөө

Бурханд “талархлаа Сүнсээр илэрхийлэх ёстой.

33 Мөн та нар “ариун журам хийгээд “цэвэр ариун байдлыг миний өмнө ямагт хэрэгжүүлэх ёстой. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 47

1831 оны гуравдугаар сарын 8-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршивой (History of the Church, 1:166). Энэ цаг үеийн өмнө Оливер Каудери Сүмийн түүхч хийгээд цэдэг хөтлөгчөөр ажиллаж байв. Жон Витмер түүхчийн томилолтыг эрэлхийлж байсангүй, гэвч, энэ орон тоонд үйлчлэхийг түүнээс асуусанд, уг асуудлаар Их Эзэний тааллыг дуулгавартай дагах болно хэмээн тэрээр хэлжээ. Нью-Йоркийн Фейеттегийн бүст хүлээн авагдсан олон илчлэлтийг цэдэглэхэд тэрээр Бошиглогчийн нарийн бичгийн даргаар өмнө нь үйлчилж байв.

1-4, Жон Витмер Сүмийн түүх хөтлөх болон Бошиглогчид зориулан бичихээр томилогдов.

БОЛГООГТУН, миний Бүйлчлэгч Жон байнгын “түүхийг бичиж мөн хөтлөх нь мөн, тэрээр цаашдын үүргүүдэд дуудагдах хүртлээ, чамд өгөгдөх бүх зүйлийг бичихэд миний үйлчлэгч Иосеф чамд туслах нь надад шаардлагатай байна.

2 Дахин, шаардлагатай ямар ч үед тэрбээр цуглаануудад

дуу хоолойгоо өргөж болно гэдгийг би чамд үнэнээр хэлж байна.

3 Мөн дахин, сүмийн цэдгийг хийгээд түүхийг байнга хөтлөх нь түүнд өгөгдсөн гэдгийг би чамд хэлнэ; учир нь Оливер Каудерийг би өөр албан тушаалд томилсон билээ.

4 Иймийн тул, тэрээр итгэлтэй байхын хэрээр эдгээр зүйлүүдийг бичих нь “Тайтгаруулагчаар түүнд өгөгдөх болно. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 48

1831 оны гуравдугаар сард Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршивой (History of the Church, 1:166–167). Гэгээнтнүүдийг суурьшуулахын тулд газар

32a Шаст. дээд 16:8–15;
1 Тес. 1:2;
Алма 37:37;
С ба Г 59:7, 21.

су Талархалтай,
Талархах, Талархал
өргөх.
33a су Нөлөөлөх хүч.

б су Ариун байдал.
47 1a С ба Г 69:2–8; 85:1–2.
4a су Тайтгаруулагч;
Ариун Сүнс.

олж авах журмын хэлбэрийн талаар Бошиглогч Их Эзэнээс асуужээ. Энэ нь тэд Огайод цугларах ёстой хэмээсэн Их Эзэний зарлигт дуулгавартай байж, Нэгдсэн Улсын дорнодоос Сүмийн гишүүд нүүдэллэх тухайд чухал асуудал байв (хэсэг 37:1-3; 45:64-ийг үз).

1-3, Огайо дахь Гэгээнтнүүд газруудаа ах дүүстэйгээ хуваалцах ёстой; 4-6, Гэгээнтнүүд газар худалдан авч, хот барьж, мөн тэргүүлэх ажилтнуудынхаа зөвлөгөөг дагах ёстой.

ЭНЭ нь та нарын нөхцөл байдлуудад тохирсон байхын хэрээр, эдүгээ үеийн тул та нар оршин суугаа газрууддаа үлдэх ёстой нь шаардлагатай бөлгөө.

2 Мөн та нар газруудтай байхын хэрээр, та нар дорно зүгийн ахан дүүстэйгээ “хуваалцах ёстой;

3 Мөн та нарт газар байхгүйн хэрээр эргэн тойрныхоо бүс нутгуудад, тэдэнд сайн санагдсанаар, эдүгээ цагийн тул тэд газар худалдан аваг, учир нь эдүгээ үеийн тул тэд амьдрах газартай байх ёстой нь зайлшгүй шаардлагатай байх ёстой.

4 Та нар хойшид газар, “бүр хотыг өв болгон ^бхудалдаж авах боломжтой байж боло-

хын тулд чадлынхаа хэрээр бүх мөнгийг хурааж, мөн та нар зөв шударга байдалд олж чадах тэр бүгдийг олж авах ёстой нь зайлшгүй шаардлагатай байх ёстой.

5 Уг газар илчлэгдэх харахан болоогүй байна; гэвч та нарын ахан дүүс дорнодоос ирсний дараа “тодорхой эрчүүд томилогдох ёстой, мөн газрыг ^бмэдэх нь тэдэнд өгөгдөх буюу тэдэнд энэ нь илчлэгдэх болно.

6 Мөн газруудыг худалдан авах, мөн “хотын суурь тавихыг эхлүүлэхээр тэд томилогдох болно; мөн тэгээд, хүн бүр ^бгэр бүлийнхээ дагуу, өөрийн нөхцөл байдлын дагуу, мөн та нарын хүлээн авсан хийгээд үүнээс хойш та нарын хүлээн авах хуулиуд хийгээд зарлигуудын дагуу мөн сүмийн ерөнхийлөгчийн зөвлөл хийгээд бишпоор түүнд томилсноор та нар гэр бүлтэйгээ хамт цугларч эхлэх ёстой. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 49

1831 оны гуравдугаар сард Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Сидней Ригдон, Парлей П.Пратт мөн Леман Коплей нарт өгөгдсөн илчлэлт оривой (History of the Church, 1:167-169). (Түүхийн зарим эх сурвалжууд энэ илчлэлтийн өдрийг 1831 оны тавдугаар сар гэсэн байдаг). Леман Коплей сайн мэдээг

48 2а су Халамж.
4а С ба Г 42:35-36;
45:65-67.

б С ба Г 57:4-5.
5а С ба Г 57:6-8.
б С ба Г 57:1-3.

6а су Шинэ
Иерусалим.
б С ба Г 51:3.

тэврэн авав, гэвч тэрээр урьд нь харьяалагддаг байсан Шейкерийн зарим заадаг зүйлүүдийг хадгалсан хэвээр байлаа. (Христийн Хоёр дахь Ирэлтэд Итгэгчдийн Нэгдсэн Нийгэмлэг). Шейкерийн зарим итгэл нь Христийн Хоёр дахь Ирэлт аль хэдийн тохиосон бөгөөд, тэрээр Анн Лий хэмээх эмэгтэй хүний дүрээр хүрч ирсэн; усаар баптисм хүртээх нь зайлиггүй чухал биш хэмээн үздэг байв; гахайн мах идэх нь онцгойлон хориглогдсон, мөн олон нь ямар ч мах иддэггүй байв; мөн ганц бие амьдрал гэрлэлтээс илүү өндөрт тооцогддог байв. Энэхүү илчлэлтийн оришилд Бошиглогч бичихдээ, “Энэ сэдвийн талаар илүү төгс ойлголттой болохын тулд Их Эзэнээс би асууж, мөн дараах зүйлийг хүлээн авсан болой” хэмээжээ (History of the Church, 1:167). Илчлэлт Шейкерийн бүлгийн үндсэн үзэл баримтлалын заримыг нь няцаав. Өмнө дурдсан ах нар уг илчлэлтийн нэг хувийг Шейкерийн бүлэгт аваачиж өгөн (Огайогийн Клевландын ойролцоо) мөн үүнийг бүгдийг нь тэдэнд уншиж өгсөн боловч энэ нь няцаагджээ.

1-7, Христийн ирэлтийн өдөр хийгээд цаг нь түүнийг иртэл мэдэгдэхгүй хэвээр үлдэнэ; 8-14, Хүмүүн авралыг олохын тулд наманчилж, сайн мэдээнд итгэн, мөн ёслолуудыг дуулгавартай дагах ёстой; 15-16, Гэрлэлт нь Бурханаар томилогдсон бөлгөө; 17-21, Мах идэх нь зөвшөөрөгддөг; 22-28, Сион цэцэглэн хөгжиж мөн леменчүүд Хоёрдахь Ирэлтийн өмнө сарнай цэцэг лугаа адил дэлгэрэх болно.

АНХААРАГТУН миний Аугийг, миний үйлчлэгчид Сидней, мөн Парлей, мөн Леман; учрыг болгоогтун, өөрсдийнхөө хүлээн авсан миний сайн мэдээг, бүр үүнийг та нар хүлээн авсныхаа дагуу та нар явж Шейкерийнхэнд “номлох ёстой хэмээх зарлигийг би та нарт өгч байна гэдгийг үнэнээр би та нарт хэлж байна.

2 Болгоогтун, би та нарт хэлнэ, тэд үнэнийг зарим талаар мэдэхийг хүсч байна, гэвч бүгдийг бус, учир нь тэд миний өмнө “зөвт бус бөгөөд наманчлах ёстой нь шаардлагатай болой.

3 Иймийн тул, миний үйлчлэгчид Сидней, мөн Парлей, сайн мэдээг тэдэнд номлохоор би та нарыг илгээж байна.

4 Мөн тэрээр тэднээс юу хүлээж авснаараа бус, харин миний үйлчлэгчид та нараар юу “заалгаснаараа тэдэнтэй хэлэлцэж болохын тулд миний үйлчлэгч Леман энэ ажилд томилогдох болно; мөн ийнхүү хийснээр нь би түүнийг адислах болно, өөрөөр тэрээр дэвжин хөгжих нь үгүй бөлгөө.

5 Их Эзэн ийнхүү хэлдэг; учир нь бибээр Бурхан билээ,

мөн дэлхийн “гэтэлгэлийн төлөө Төрсөн Ганц Хүүгээ дэлхийд ^билгээсэн болой, мөн түүнийг хүлээн авсан нь аврагдах болно, мөн түүнийг хүлээн аваагүй нь ^вяллагдах болно гэдгийг тогтоосон ажгуу —

6 Мөн Хүний “Хүүд тэд өөрсдийнхөө хүссэнийг үйлдсэн билээ; мөн тэрээр өөрийн сур хүчийг ^балдар суугийнхаа ^вбаруун гар дээр авч, мөн эдүгээ тэнгэрт хаанчилж буй, мөн дэлхий дээр бууж ирэн бүх дайснуудыг хөл ^дороо оруулах хүртлээ хаанчлах болно, энэ цаг ойрхон байна —

7 Их Эзэн, бибээр, үүнийг ярилаа; гэвч тэрхүү цаг хийгээд “өдрийг мэдэх хүмүүн үгүй, тэрчлэн тэнгэрт буй тэнгэр элчүүд ч үгүй бөгөөд, тэд түүнийг иртэл мэдэх нь үгүй.

8 Иймийн тул, бүх хүмүүн наманчлах ёстой хэмээн хүснэ би, учир нь миний өөртөө нөөцөлсөн, та нарын үл мэдэх тэрхүү “ариун хүмүүсээс бусад нь бүгд ^бнүгэл дор буй.

9 Иймийн тул, бүр эхлэлээс байсан өөрийн үүрдийн “гэ-

рээг та нарт би илгээсэн гэдгийг би та нарт хэлж байна.

10 Мөн би амласан зүйлээ тэрчлэн биелүүлсэн болой, мөн дэлхийн “үндэстнүүд үүнд ^бмэхийх болно; мөн хэрэв тэднээс өөрсдөөс нь бус аваас, тэд дорд болгогдох болно, учир нь эдүгээ өөрөөсөө өргөмжлөгдсөн тэр нь “дорд хүчинд тавигдах болно.

11 Иймийн тул, би та нарт нэг зарлиг өгч байна, та нар энэ хүмүүсийн дунд “яв мөн нэр нь Петр болох миний эртний төлөөлөгчийн адилаар тэдэнд хэл:

12 Дэлхий дээр байсан, мөн ирэх, эхлэл ба төгсгөл болох Их Эзэн Есүс Христийн нэрэнд итгэ;

13 “Наманчил, мөн ариун зарлигийн дагуу нүглүүдийнхээ ангижралын тулд Есүс Христийн нэрээр баптисм хүртэгтүн;

14 Мөн үүнийг хийдэг хэн боловч сүмийн ахлагчид толгой дээр нь “гар тавьснаар Ариун Сүнсний ^ббэлгийг хүлээн авах болно.

15 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлнэ, гэрлэхийг “хориг-

5а су Гэтэлгэх,
Гэтэлгэгдэх,
Гэтэлгэл;
Гэтэлгэгч.
б Иохан 3:16–17;
С ба Г 132:24.
су Есүс Христ—
Эрх мэдэл.
в су Ял.
6а су Хүний Хүү.
б су Есүс Христ—
Есүс Христийн
алдар суу.
в Үйлс 7:55–56;

С ба Г 76:20–23.
г 1 Кор. 15:25;
С ба Г 76:61.
7а Мат. 24:36;
Марк 13:32–37;
Илч. 16:15;
С ба Г 133:11.
8а Евр. 13:2;
3 Ниф. 28:25–29.
б Гал. 3:22;
Мозая 16:3–5.
9а Эхл. 17:7;
С ба Г 66:2.
су Шинэ бөгөөд

үүрдийн Гэрээ.
10а Зех. 2:11;
С ба Г 45:66–69;
97:18–21.
б Иса. 60:14.
в Мат. 23:12.
11а су Номлолын
ажил.
13а 3 Ниф. 27:19–20.
14а су Гар Тавих.
б су Ариун Сүнсний
бэлэг.
15а 1 Тим. 4:1–3.

лодог хэн боловч Бурханаас томилогдоогүй болой, учир нь ^бгэрлэлт нь Бурханаас хүмүүнд томилогдсон билээ.

16 Иймийн тул, хүн нэг “эхнэртэй байх ёстой нь хууль ёсны юм, мөн хоёул ^бнэг махбодь байх болно, мөн энэ бүгд нь өөрийн бүтээлтийн зорилгыг ^бдэлхий хэрэгжүүлж болохын тулд юм;

17 Мөн ийнхүү дэлхий бий болгогдохоос “өмнөх түүний ^ббүтээлтийн дагуу энэ нь хүмүүний тоо хэмжээгээр дүүргэгдэх болно.

18 Мөн хүмүүн “махнаас татгалзаж, үүнийг идэх ёсгүй хэмээн ^бхориглодог хэн боловч Бурханаас томилогдоогүй бөлгөө;

19 Учир нь, болгоогтун, хээрийн “амьтад мөн огторгуйн жигүүртнүүд, мөн газраас гардаг зүйл нь хоол хүнс хийгээд хувцас хунарын тулд хүмүүний хэрэгцээнд мөн түүнд элбэг дэлбэгээр байж болохын тулд томилогдсон бөлгөө.

20 Гэвч энэ нь нэг хүн нөгөөгөөс илүү ихийг “эээмшихийн тулд өгөгддөггүй, үүний ул-

маас ^бдэлхий нүгэлд байдаг буюу.

21 Мөн хэрэгцээгүй атлаа цус “урсгагч эсвээс махыг үрэгч хүмүүнд халаг.

22 Мөн дахин, Хүний Хүү эмэгтэй хүний дүрээр эсвээс дэлхий дээр аялагч эрэгтэй хүний дүрээр ч “ирэх нь үгүй гэдгийг үнэнээр би та нарт хэлж байна.

23 Иймийн тул, бүү “мэхлэгд, харин тэнгэр сэгсрэгдэхийг, мөн дэлхий чирчирхийлж согтуу хүн мэт ийш тийш дайвалзан ганхахыг, мөн ^бхөндий талууд өргөгдөхийг, мөн “уулс намхан болгогдохыг, мөн бартаатай газрууд тэгш болохыг — мөн тэнгэр элч ^ббүрээгээ үлээхэд энэ бүхэн тохиохыг ^бхүлээн гуйвшгүй байдалд үргэлжлүүл.

24 Гэвч Их Эзэний агуу өдөр ирэхийн өмнө “Иаков аглаг буйдад цэцэглэн хөгжих болно, мөн леменчүүд сарнай цэцэг лугаа адил ^бдэлгэрэх болно.

25 Сион “толгод дээр ^бцэцэглэн хөгжиж мөн уулс дээр баясах болно, мөн ми-

15б Эхл. 2:18, 24;
1 Кор. 11:11.
су Гэрлэлт, Гэрлэх.
16а Иаков 2:27–30.
б Эхл. 2:24;
Мат. 19:5–6.
в су Газар дэлхий—
Хүмүүнд зориулан
Бүтээгдэв.
17а су Мөнх бус
байдлын өмнөх
амьдрал.
б Мосе 3:4–5.
су Бүтээх, Бүтээл.

18а Эхл. 9:3;
1 Тим. 4:1–3.
б өх Татгалзахыг
хүсэх.
19а С ба Г 89:10–13.
20а Үйлс 4:32;
С ба Г 51:3;
70:14; 78:6.
б су Дэлхийнх.
21а исо, Эхл. 9:10–15.
22а су Есүс Христийн
Хоёр дахь Ирэлт.
23а Мат. 24:4–5.
б Иса. 40:4;

С ба Г 109:74.
в Мика 1:3–4.
г Мат. 24:29–31.
д 2 Петр 3:12;
С ба Г 45:39.
24а 3 Ниф. 5:21–26.
б Иса. 35:1;
2 Ниф. 30:5–6;
3 Ниф. 21:22–25;
С ба Г 3:20; 109:65.
25а Эхл. 49:26;
2 Ниф. 12:2–3.
б С ба Г 35:24.

ний томилсон тэрхүү газарт хамтдаа цугларах болно.

26 Болгоогтун, би та нарт хэлнэ, та нарт миний зарлигласнаар урагш явагтун; бүх нүглээсээ наманчил; “асуу, тэгвэл та нар хүлээж авах болно, тогш, тэгвэл энэ нь та нарт нээгдэх болно.

27 Болгоогтун, би та нарын өмнө явж мөн та нарын ар талын “хамгаалагч байх болно; мөн би та нарын дунд байх болно, бас та нар дийлэгдэх нь үгүй.

28 Болгоогтун, бибээр Есүс Христ билээ, мөн би “гэнэт ирнэ. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 50

1831 оны тавдугаар сард Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:170–173). Дэлхий даяар тархсан янз бүрийн сүнсний илэрхийллүүдийг ахлагчдын зарим нь ойлгохгүй байсныг мөн уг асуудлын талаар тэрбээр тусгайлан асуусны хариу болгон энэхүү илчлэлт өгөгдсөнийг Бошиглогч өгүүлжээ. Ер бусын сүнсний үзэгдэл хэмээгдэгч нь гишүүдийн дунд нийтлэг бус байлаа, тэдний зарим нь үзэгдлүүд хийгээд илчлэлтүүд хүлээн авдаг мэтээр мэдэгдэв.

1–5, Олон хуурамч сүнс дэлхийд тархсан ажгуу; 6–9, Хоёр нүүр гаргагчдад мөн Сүмээс тусгаарлагдагсдад халаг; 10–14, Ахлагчид Сүнсээр сайн мэдээг номлох ёстой; 15–22, Номлогчид хийгээд сонсогчид аль аль нь Сүнсээр гэгээрүүлэгдэх хэрэгтэй; 23–25, Сэнхрүүлдэггүй тэр нь Бурханаас биш бөлгөө, 26–28, Итгэлтнүүд бүх зүйлийн эзэмшигчид болой; 29–36, Цэвэршигдсэн тэдний залбирлууд харуулагддаг; 37–46, Христ бол Сайн Хоньчин мөн Израилын Чулуу болой.

АНХААРАГТУН, Ай миний Сүмийн ахлагчид та нар, мөн амьд Бурханы дуу хоо-

лойд чих тавигтун; мөн сүмийн талаар бас дэлхийд тархсан олон сүнсний талаар санал нэгтэй байсан хийгээд та нар асуусныхаа дагуу та нарт өгөгдөх мэргэн ухааны үгсэд анхаарал хандуулагтун.

2 Болгоогтун, үнэнээр би та нарт хэлж байна, “хуурамч сүнснүүд болох олон сүнс буй, тэдгээр нь дэлхийд тархан, дэлхийг мэхэлж байна.

3 Мөн тэрчлэн тэрээр та нарыг унагааж болохын тулд “Сатан та нарыг мэхлэхээр эрэлхийлсээр байна.

4 Болгоогтун, Их Эзэн бибээр, та нарын дээрээс харлаа, мөн миний нэрийг

26а С ба Г 88:63.

27а Иса. 52:12.

б 3 Ниф. 20:22.

в 1 Петр 2:6;

С ба Г 84:116.

28а С ба Г 1:12.

50 2а С ба Г 129.

су Сүнс—Муу ёрын

сүнснүүд.

3а Лук 22:31;

3 Ниф. 18:18.

“тунхагладаг сүм дэх жигшүүрт хэргүүдийг харлаа.

5 Гэвч итгэлтэй хийгээд эцсээ хүртэл “тэвчдэг тэд амьдралд ч эсвээс үхэлд ч адислагдсан болой, учир нь тэд мөнх амьдралыг өвлөх болно.

6 Гэвч “мэхлэгчид хийгээд хоёр нүүртэн тэдэнд халаг, учир нь, бибээр тэднийг шүүлтэнд авчирна хэмээн Их Эзэн ийн хэлдэг билээ.

7 Болгоогтун, заримыг нь мэхэлж, энэ нь “дайсанд ^бхүч өгсөн “хоёр нүүртнүүд та нарын дунд байна гэдгийг үнэнээр би та нарт хэлнэ; гэвч болгоогтун ^ииймүүд нь буцаан авчрагдах болно;

8 Гэвч хоёр нүүртнүүд амьдралд буюу үхэлд аль алинд нь, бүр миний хүсдэгчлэн, илрүүлэгдэж мөн тусгаарлагдах болно; мөн миний сүмээс “тусгаарлагдсан тэдэнд халаг, учир нь мөнхүү тэд бол дэлхийд дийлэгдэгсэд болой.

9 Иймийн тул, үнэнд бус хийгээд зөв шударга бус зүйлийг миний өмнө үйлдэхгүйн тулд хүн бүр болгоомжил.

10 Мөн эдүгээ та нар ойлгож болохын тулд нааш ир мөн хамтдаа “хэлэлцье хэ-

мээн Их Эзэн Ариун Сүнсээр сүмийнхээ ахлагчдад хэлдэг;

11 Бүр хүн бие биетэйгээ нүүр нүүрээрээ тулан хэлэлцдэгийн адил бүгдээрээ хэлэлцье.

12 Эдүгээ, хүн хэлэлцэхэд хүмүүс түүнийг ойлгодог, учир нь тэрээр хүнтэй адил хэлэлцдэг буюу; та нар “ойлгож болохын тулд Их Эзэн бибээр та нартай бүр түүнчлэн хэлэлцэх болно.

13 Иймийн тул, Их Эзэн бибээр та нараас энэ асуултыг асууя— та нар юунд “томилогдсон бэ?

14 Үнэнийг заахаар урагш илгээгдсэн, бүр “Тайтгаруулагч болох ^сСүнсээр миний сайн мэдээг номлохоор буюу.

15 Мөн тэгээд та нар өөрсдөө ойлгож чадаагүй тэрхүү “сүнснүүдийг та нар хүлээн авсан билээ, мөн тэдгээрийг Бурханаас байсан мэтээр хүлээн авсан буюу; мөн үүнд та нар зөвтгөгдөх гэж үү?

16 Болгоогтун та нар энэ асуултыг өөрсдөө хариулах ёстой, гэсэн хэдий ч, би та нарт энэрэнгүй байх болно; та нарын дундах сул дорой нэгэн нь үүнээс хойш “хүчтэй болгогдох болно.

17 Үнэнээр би та нарт хэл-

4а су Есүс Христ—
Өөрсөд дээрээ
Есүс Христийн
нэрийг авах.

5а су Тэвчих.

6а су Заль, Залилах,
Залилан.

7а су Чөтгөр.

б Мозая 27:8–9.

в Мат. 23:13–15;

Алма 34:28.

г ө.х. Залилагдсан
хүмүүс.

8а С ба Г 1:14;

56:3; 64:35.

су Сүмээс хөөх.

10а Иса. 1:18;

С ба Г 45:10.

12а С ба Г 1:24.

13а су Томилох,

Томилолт.

14а су Тайтгаруулагч.

б С ба Г 43:15.

су Заах, Багш—

Сүнсээр заах.

15а су Ялган таних

бэлэг.

16а Ифер 12:23–27.

нэ, тэрээр надаар томилогдож мөн Тайтгаруулагчаар үнэний үгийг “номлохоор үнэний ^бСүнсэнд, урагш илгээгдэхдээ, үүнийг тэрээр үнэний Сүнсээр номлох уу эсвэл ямар нэг өөр зам бий юү?

18 Мөн хэрэв энэ нь ямар нэг өөр замаар болбоос энэ нь Бурханаас бус болой.

19 Мөн дахин, үнэний үгийг хүлээн авдаг тэрээр үүнийг үнэний Сүнсээр хүлээн авдаг уу, эсвэл өөр ямар нэг зам бий юү?

20 Мөн хэрэв энэ нь ямар нэг өөр замаар болбоос энэ нь Бурханаас бус болой.

21 Тиймийн тул, үгийг үнэний Сүнсээр хүлээн авдаг тэрээр үүнийг үнэний Сүнсээр номлогдсоны дагуу хүлээн авдаг гэдгийг та нар яагаад ойлгож мөн мэдэж чадахгүй байна вэ?

22 Иймийн тул, номлодог тэр нь мөн хүлээн авдаг тэр нь бие биенээ ойлгодог, мөн хоёул “сэнхэрч мөн хамтдаа ^ббаясдаг буюу.

23 Мөн сэнхэрдэггүй тэр нь Бурханаас бус, мөн “харанхуй болой.

24 Бурханаас буй тэр нь “гэрэл болой; мөн гэрлийг хүлээн авдаг мөн Бурханд

^бүлддэг тэр нь “илүү их гэрэл хүлээн авдаг; мөн тэрхүү гэрэл төгс өдрийг хүртэл улам улам хурц болон өсдөг.

25 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлдэг, та нар “үнэнийг мэдэж болохын тулд, та нар өөрсдийнхөө дундаас харанхуйг үлдэн хөөж болохын тулд мөн бибээр үүнийг хэлж байна;

26 Бурханаар томилогддог мөн урагш илгээгддэг тэр нь хамгийн дорд хийгээд бүхний “үйлчлэгч байлаа ч гэсэн ^бхамгийн агуу нэгэн байхаар томилогддог мөнхүү тэр нь буюу.

27 Иймийн тул, тэр нь бүх зүйлсийг “эзэмшигч билээ; учир нь Эцэгийн тааллаар түүний Хүү Есүс Христээр дамжуулан урагш илгээгдсэн тэнгэр хийгээд дэлхий аль алин дээрх амьдрал хийгээд гэрэл, Сүнс хийгээд ^бсүр хүч бүх зүйл түүнд захирагддаг бөлгөө.

28 Гэвч бүх нүглээс үл “ариусгагдаж мөн үл ^бцэвэршигдэх аваас, хүмүүн бүх зүйлийн эзэмшигч байх нь үгүй.

29 Мөн хэрэв та нар бүх нүглээс ариусгагдаж мөн цэвэршигдэх аваас, та нар Есүсийн нэрээр юуг ч хүсч

17а су Номлолын ажил; Номлох.
 б С ба Г 6:15.
 су Ариун Сүнс; Үнэн.
 22а 1 Кор. 14:26.
 б Иохан 4:36.
 23а су Сүнсний харанхуй.
 24а 1 Иохан 2:8–11;

Моро. 7:14–19;
 С ба Г 84:45–47;
 88:49.
 су Гэрэл, Христийн гэрэл.
 б Иохан 15:4–5, 10.
 в 2 Ниф. 28:30.
 25а Иохан 8:32.
 26а Марк 10:42–45.
 су Үйлчлэл.

б Мат. 23:11.
 27а С ба Г 76:5–10,
 53–60; 84:34–41.
 б су Хүч.
 28а 3 Ниф. 19:28–29;
 С ба Г 88:74–75.
 су Цэвэр ариун,
 Цэвэр ариун байдал; Ариусгал.
 б 1 Иохан 1:7–9.

“асуулаа гэсэн мөн энэ нь хийгдэх болно.

30 Гэвч та нарын юу асуух ёстой чинь та нарт өгөгдөх болно гэдгийг мэд; мөн чи “тэргүүнээр томилогдсон учраас сүнснүүд чамд захирагдах болно.

31 Иймийн тул, мөнхүү улиран тохиох дор, хэрэв өөрсдийн тань ойлгож үл чадах илэрхийлэгдсэн “сүнснийг та нар болгоох аваас, мөн та нар тэр сүнснийг үл хүлээн авбаас, Есүсийн нэрээр Эцэгээс асуух ёстой; мөн хэрэв тэрээр уг сүнснийг та нарт үл өгөх аваас, тэгвэл та нар үүнийг Бурханаас бус гэдгийг мэдэж болох бөлгөө.

32 Мөн тэрхүү сүнсний дээрх “хүч та нарт өгөгдөх болно; мөн тэрхүү сүнсний эсрэг та нар чанга дуу хоолойгоор энэ нь Бурханаас бус хэмээн тунхаглах ёстой—

33 Та нар үүнд дийлдэхгүйн тулд “хатуу ширүүн буруутгалаар бус, мөн та нар үүндээ баригдахгүйн тулд ^бонгирон сагсуурах буюу баярлан хөөрсөн байдлаар бус буюу.

34 Бурханаас хүлээн авдаг тэрээр, үүнийг Бурханаас хэмээн тооцог; мөн тэрээр хүлээн авахад зохистой хэмээн Бурханаар тооцогдсондоо баясаг.

35 Мөн та нар хүлээн авсан мөн үүний дараа хүлээн авах тэдгээр зүйлдээ анхаарал тавьж мөн үйлдсэнээр буюу—мөн Эцэгээс та нарт “хаант улс, мөн түүнээс томилогдоогүй бүх зүйлийг дийлэх ^бхүч өгөгдсөн бөлгөө—

36 Мөн болгоогтун, үнэнээр би та нарт хэлнэ, миний эдгээр үгсийг миний үйлчлэгчийн амнаас эдүгээ сонсож буй та нар адислагдсан болой, учир нь нүглүүд тань та нарт “өршөөгдсөн бөлгөө.

37 Миний таалалд орших миний үйлчлэгч Жосеф Веикфилд, мөн миний үйлчлэгч “Парлей П.Пратт сүмүүдийн дунд урагш явж мөн ^бухуулгын үгсээр тэднийг хүчирхэгжүүлэг;

38 Мөн тэрчлэн миний үйлчлэгч Жон Корилл, эсвээс миний үйлчлэгчдээс энэ албан тушаалд томилогдсон олон нь мөн “талбайд хөдөлмөрлөг; мөн ямар ч хүн тэдэнд миний томилсон тэдгээрийг үйлдэхэд нь бүү саад болог—

39 Иймийн тул, энэ зүйлүүдээс миний үйлчлэгч “Эдвард Партриж зөвтгөгдөх нь үгүй болой; харин тэрээр наманчлаг мөн тэрээр өршөөгдөх болно.

40 Болгоогтун, та нар бяцхан хүүхдүүд, мөн эдүгээ та нар

29a Хил. 10:5;
С ба Г 46:30.
су Залбирал.

30a су Эрх мэдэл.

31a 1 Иохан 4:1.

су Сүнс—Муу ёрын сүнснүүд.

32a Мат. 10:1.

33a Иудей 1:9.

б С ба Г 84:67, 73.

35a су Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс.

б 1 Иохан 4:4;

С ба Г 63:20, 47.

36a С ба Г 58:42–43.

су Уучлах.

37a су Парлей, Пратт Паркер.

б С ба Г 97:3–5.

38a су Их Эзэний талбай.

39a су Эдвард Партриж.

бүх зүйлийг “даах нь үгүй болой; та нар ^бач ивээл хийгээд “үнэний мэдлэгт ‘өсөх ёстой.

41 Бяцхан “хүүхдүүд бүү ^бэмээ, учир нь та нар минийх болой, мөн бибээр дэлхийг “ялсан, мөн та нар Эцэгийн надад ‘өгсөн тэдний хэсэг билээ;

42 Миний Эцэгийн надад өгсөн тэднээс хэн нь ч “алдагдах нь үгүй.

43 Мөн Эцэг хийгээд бибээр “нэг болой. Бибээр Эцэгийн дотор мөн Эцэг миний дотор байдаг; мөн та нар намайг

хүлээн авахын хэрээр, та нар миний дотор мөн бибээр та нарын дотор байдаг бөлгөө.

44 Иймийн тул, бибээр та нарын дунд байна, мөн бибээр “сайн хоньчин, мөн Израилын ^бчулуу болой. Энэ “хадан дээр барьдаг тэр нь ‘хэзээ ч нурахгүй байх болно.

45 Мөн өдөр нь ирэхэд та нар миний дуу хоолойг сонсож мөн намайг “харах болно, мөн би байдгийг мэдэх болно.

46 Тиймээс та нар “бэлэн байж болохын тулд ^бсэрэмжтэй байгтун. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 51

1831 оны тавдугаар сард Огайогийн Томпсонд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:173–174). Энэ үед дорнод мужуудаас нүүдэллэсэн Гэгээнтнүүд Огайод ирж эхэлж байлаа, мөн тэдний суурьшилтын тулд зохион байгуулалтын тодорхой арга хэмжээнүүд авах шаардлагатай байв. Энэ ажил үүрэг нэн ялангуяа бишопын албан тушаалд хамаарагдаж байсан болохоор, Бишоп Эдвард Партриж уг асуудлаар заавар эрэлхийлж, мөн Бошиглогч Их Эзэнээс асуужээ.

1–8, Эдвард Партриж ажил үүрэг болон өмч хөрөнгийг зохицуулахаар томилогдов; 9–12, Гэгээнтнүүд шударгаар хандаж мөн эн тэнцүү хүлээж авах ёстой; 13–15, Тэд бишопын агуулахтай байж мөн Их Эзэний

хуулийн дагуу өмч хөрөнгийг зохион байгуулах ёстой; 16–20, Огайо бол түр зуур цугларах газар байх ёстой.

АНХААРАГТУН, намайг хэмээн Их Эзэн Бурхан

40a 3 Ниф. 17:2–3;
С ба Г 78:17–18.

б су Ач ивээл.
в су Үнэн.

г 1 Кор. 3:2–3;
С ба Г 19:22–23.

41a су Бурханы хөвгүүд охид.
б 1 Иохан 4:18.
в Иохан 16:33.

г Иохан 10:27–29; 17:2;

3 Ниф. 15:24;
С ба Г 27:14; 84:63.

42a Иохан 17:12;
3 Ниф. 27:30–31.

43a Иохан 17:20–23;
3 Ниф. 11:35–36.
су Бурхан, Бурхан Тэргүүтэн.

44a Иохан 10:14–15.
су Сайн Хоньчин.
б Эхл. 49:24;

1 Петр 2:4–8.
су Булангийн тулгуур чулуу.

в 1 Кор. 10:1–4.
су Хад; Есүс Христ.
г Хил. 5:12.

45a С ба Г 67:10–13.

46a Алма 34:32–33.

б су Харах, Харуул.

чинь өгүүлж байна, мөн бибээр өөрийн үйлчлэгч “Эдвард Партрижид хэлж, мөн түүнд заавруудыг өгөх болно; учир нь энэ хүмүүсийг хэрхэн зохион байгуулах заавруудыг тэрээр хүлээж авах ёстой нь шаардлагатай ажгуу.

2 Учир нь тэд миний “хуулиудын дагуу зохион байгуулагдах ёстой нь шаардлагатай байна; хэрэв эс тэгвээс, тэд тусгаарлагдах болно.

3 Иймийн тул, миний үйлчлэгч Эдвард Партриж хийгээд түүний сонгосон миний таалалд нийцэх тэд, энэ хүмүүст хүн болгонд гэр бүлийнх нь дагуу, нөхцөл боломжийнх нь дагуу мөн хүсэл хийгээд “хэрэгцээнийх нь дагуу ⁶адил тэгшээр хувийг нь олгог.

4 Мөн миний үйлчлэгч Эдвард Партриж, тэрээр хүнд өөрийнх нь хувийг олгохдоо, түүнд хувийг нь ноогдуулсан бичгийг, бүр сүм дэх энэ эрх хийгээд энэ өвийг тэрээр зөрчил гаргаж, сүмийн хуулиуд хийгээд “гэрээнүүдийн дагуу сүмд харьяалагдах нь, мөн сүмийн дуу хоолойгоор зохистой гэж тооцогдохгүй болох үеийг

хүртэл тэрээр үүнийг эзэмшихийн тулд түүнд олгог.

5 Мөн тэрээр зөрчил гаргаж мөн сүмд харьяалагдах нь зохистой гэж тооцогдохгүй болох аваас, миний сүмийн ядуус хийгээд гачигдагсдад зориулж бишопт ариулан адисалсан өөрийн хувийг тэрээр шаардах хүч үгүй байх болно, тиймээс тэрээр бэлгийг хадгалж чадахгүй, харин гагцхүү өөртөө ноогдох хэсгийг л шаардах ёстой.

6 Мөн уг нутгийн “хуулиудын ⁶дагуу бүх зүйл ийн баттай болгогдох ёстой.

7 Мөн энэ хүмүүст харьяалагддаг тэр зүйл нь, энэ хүмүүст олгогдог.

8 Мөн энэ хүмүүст үлдэх “мөнгө нь — энэ хүмүүсийн хэрэгцээний дагуу хүнс болон хувцсаар хангахын тулд уг ⁶мөнгийг авах нэг төлөөний хүн энэ хүмүүст томилогдог.

9 Мөн та нар, бүр миний зарлигласнаар “нэг байж болохын тулд хүн бүр ⁶шударгаар үйлдэж мөн энэ хүмүүсийн дунд эрх тэгш байг, мөн эн тэнцүү хүлээн аваг.

10 Мөн энэ хүмүүст харьяалагдах тэр зүйл нь авагдаж мөн “өөр сүмд өгөгдөх ёсгүй.

51 1a су Эдвард Партриж.

2a С ба Г 42:30–39; 105:5.

су Өргөл болгох, Өргөлийн хууль.

3a Үйлс 2:44–45;

4 Ниф. 1:2–3.

б С ба Г 49:20.

4a ө.х. Хэсэг 20, 22 Есүс

Христийн Сүмийн Тунхаг болон Гэрээ хэмээн нэрлэгдэг. С ба Г 33:14; 42:13. су Гэрээ.

6a С ба Г 58:21–22.

б 1 Петр 2:13;

С ба Г 98:5–7.

8a С ба Г 84:104.

б С ба Г 104:15–18.

9a С ба Г 38:27.

су Эв нэгдэл.

б су Үнэнч, Үнэнч байдал.

10a ө.х. Сүмийн өөр нэгэн салбар буюу өөр нэгэн шашны бүлэг.

су Нийтийн

дэмжлэг.

11 Иймийн тул, хэрэв өөр сүм энэ сүмээс мөнгө хүлээн авах болбол, тэд тохирсныхоо дагуу энэ сүмд буцаан төлөг;

12 Мөн энэ нь бишоп буюу сүмийн “дуу хоолойгоор томилогдох төлөөний хүнээр дамжин хийгдэх ёстой.

13 Мөн дахин, бишоп энэ сүмд “агуулах бий болгог; мөн энэ хүмүүсийн хүслүүдийн тулд “шаардлагатайгаас илүү бүх зүйл, мөнгөөр болон хүнсээр аль алинаар нь, бишопын гарт хадгалагдаг.

14 Мөн тэрээр энэ ажлыг хийж буйн учир үүнийг эрхлэх үед гэр бүлийнхээ хүсэлд зориулж мөн тэрээр өөрийнхөө хүсэлд зориулан өөртөө тэрчлэн нөөцлөг.

15 Мөн ийнхүү миний “хуулиудын дагуу, өөрсдийгөө зохион байгуулах онцгой боломжийг би энэ хүмүүст олгож байна.

16 Мөн бибээр тэдэнд “энэ

нутгийг богинохон хугацаанд, Их Эзэн бибээр тэднийг өөр байдлаар хангаж, мөн эндээс явахыг тэдэнд зарлиглах хүртлээ ариулан адислаж байна;

17 Мөн тэр цаг хийгээд өдөр нь тэдэнд өгөгдөөгүй болой, иймийн тул тэд энэ нутагт олон жил байх мэтээр үйлдэг, мөн энэ нь тэдний сайн сайхан байдал болж тэдэнд хувирах болно.

18 Болгоогтун, энэ нь миний үйлчлэгч Эдвард Партрижид, бусад газруудад, бүх сүмд “үлгэр жишээ болох ёстой.

19 Мөн итгэлтэй, үнэнч шударга, ухаалаг “даамал байсан хэн нь ч гэсэн Их Эзэнийхээ “баяр баясгаланд орж, мөн мөнх амьдралыг өвлөх болно.

20 Үнэнээр, би та нарт хэлнэ, би бол чиний санаагүй “цагт, гэнэт “бирэх Есүс Христ бөлгөө. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 52

1831 оны зургадугаар сарын 7-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Сүмийн ахлагчдад өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:175–179). Зургадугаар сарын 3-нд эхэлж 6-нд дууссан чуулган Көртландад болжээ. Энэ чуулган дээр дээд санваартны албан тушаалд тусгайлан томилсон анхны томилолтууд болж, мөн хуурамч хийгээд мэхлэгч сүнснүүдийн зарим тунхаглалууд ялган танигдаж мөн зэмлэгджээ.

<p>12a су Нийтийн дэмжлэг. 13a С ба Г 42:55. су Агуулах. б С ба Г 42:33–34, 55; 82:17–19.</p>	<p>15a С ба Г 51:2. 16a ө.х. Көртланд, Огайо бүс. 18a ө.х. Загвар. 19a Мат. 24:45–47. су Даамал, Ажил</p>	<p>үүрэг. б су Баяр баясгалан. 20a Мат. 24:44. б Илч. 22:6–16.</p>
---	---	--

1–2, Дараагийн чуулган Миссурид болохоор товлогдов; 3–8, Хамтаараа аянд гарах зарим ахлагчид томилогдов; 9–11, Төлөөлөгчид хийгээд бошиглогчдын бичсэнийг ахлагчид заах ёстой; 12–21, Сүнсээр гэгээрсэн тэд магтаал хийгээд мэргэн ухааны үр жимсийг авчирдаг; 22–44, Олон ахлагч чуулганд оролцохоор Миссури уруу явах замдаа сайн мэдээг номлохоор томилогдов.

БОЛГООГТУН, Их Эзэн Бөөрөө “дуудаж мөн эдгээр эцсийн өдрүүдэд сонгосон ахлагчдад Сүнснийхээ дуу хоолойгоор ийн хэлэв —

2 Өгүүлрүүн: Энэ цагаас эхлэн Миссурид, Иаковын “үлдэгдэл болох өөрийн хүмүүсийг мөн ^бгэрээний дагуу өв залгамжлагчид болох тэдэнд миний ^аариулан адислах тэрхүү ^нутагт болох дараагийн чуулган хүртэл та нар юу хийх ёстой тухайд Их Эзэн бибээр өөрийн тааллыг та нарт мэдүүлэх болно.

3 Иймийн тул, үнэнээр би та нарт хэлнэ, миний үйлчлэгчид Бага Иосеф Смит, Сидней Ригдон, гэр орноо орхин явах бэлтгэл нь аль болох түргэн хийгдмэгц мөн Миссури нутаг уруу аялаг.

4 Мөн тэд надад итгэлтэй

байхын хэрээр, тэд юу хийх нь тэдэнд мэдүүлэгдэх болно; 5 Мөн тэд итгэлтэй байхын хэрээр, та нарын өвийн “нутаг тэрчлэн тэдэнд мэдүүлэгдэх болно.

6 Мөн тэд итгэлгүй байхын хэрээр, бүр миний хүссэнээр, надад сайн санагдсанаар, тэд тусгаарлагдах болно.

7 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлнэ, миний үйлчлэгч Лайман Вайт, мөн миний үйлчлэгч Жон Корилл нар аян замдаа үтэр түргэн гараг;

8 Мөн тэрчлэн миний үйлчлэгч Жон Мурдок, мөн миний үйлчлэгч Хайрум Смит, Детройтын замаар дамжин мөнхүү тэр газар уруу аян замдаа гарагтун.

9 Мөн “бошиглогчид хийгээд төлөөлөгчдийн бичсэнээс, мөн итгэлийн залбирлаар дамжин ^бТайтгаруулагчаар тэдэнд заагдах тэр зүйлээс өөр ^аямар ч зүйлүүдийг үл ярин, замдаа үгийг номлон тэд тэндээс аялаг.

10 Тэд “хоёр хоёроороо яваг, мөн ийн тэд зам зууртаа ^бусаар баптисм хүртээн мөн усны хажууд ^агар тавин, цугласан болгонд номлог.

11 Учир нь Их Эзэн ийн хэлдэг, бибээр өөрийн ажлыг “зөв шударгад түргэсгэх болно, учир нь бибээр шүүлтийг

52 1a су Дуудах,

Бурханаас дуудагдах, Дуудлага.

2a Дуул. 135:4;

3 Ниф. 5:21–26.

б Абр. 2:6–11.

су Абрахамын

гэрээ.

в С ба Г 58:57; 84:3–4.

г С ба Г 57:1–3.

5a С ба Г 57:1–3.

9a С ба Г 42:12; 52:36.

су Судрууд.

б су Тайтгаруулагч;

Ариун Сүнс;

Заах, Багш—

Сүнсээр заах.

в Мозая 18:19–20.

10a Марк 6:7;

С ба Г 61:35.

б Иохан 1:26.

в Үйлс 8:14–17.

11a Ром 9:28.

ялалтад урагш илгээх тэрхүү өдрүүд ирэх бөлгөө.

12 Мөн миний үйлчлэгч Лайман Вайт болгоомжлогч, учир нь Сатан түүнийг тарианы хог мэт “шигшихийг хүсдэг.

13 Мөн болгоогтун, “итгэлтэй тэр нь олон зүйлийн дээр захирагч болгогдох болно.

14 Мөн дахин, та нар мэхлэгдэхгүй байж болохын тулд бибээр та нарт бүх зүйлд загвар өгнө; учир нь Сатан уг нутагт тархсан байна, мөн тэрээр үндэстнүүдийг мэхлэхээр урагш одох ажгуу—

15 Иймийн тул хэрэв тэрээр миний “ёслолуудыг дуулгавартай дагах аваас, сүнс нь ^бгэмшдэг, залбирдаг тэрээр, мөнхүү тэр нь надаас ^ххүлээн зөвшөөрөгддөг бөлгөө.

16 Хэрэв тэрээр миний ёслолуудыг дуулгавартай дагах аваас, ярьдаг, сүнс нь гэмшдэг, хэл нь даруу төлөв хийгээд сэнхрүүлдэг тэрээр, мөнхүү тэр нь Бурханых бөлгөө.

17 Мөн дахин, миний сүр хүчин дор дагжин чичрэх тэрээр та нарт миний өгсөн илчлэлтүүд хийгээд үнэнүүдийн дагуу “хүчтэй болгогдох болно, мөн, магтаалын хийгээд ^бмэргэн ухааны үр жимсийг урагш авчрах болно.

18 Мөн дахин, дийлдэж мөн үр жимсийг урагш эс ^аавчрах тэрээр, бүр энэ загварын

дагуу байлаа ч, минийх биш авай.

19 Иймийн тул, энэ загвараар та нар тэнгэрийн дор хаана ч бүх тохиолдолд сүнснүүдийг “мэдэх болно.

20 Мөн уг өдрүүд ирээд байна; хүмүүний итгэлийн дагуу энэ нь тэдэнд “хийгдэх болно.

21 Болгоогтун, энэхүү зарлиг нь миний сонгож авсан бүх ахлагчдад өгөгдөх болно.

22 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлнэ, миний үйлчлэгч “Томас Б. Марш мөн миний үйлчлэгч Эзра Тайре нар явах замдаа мөнхүү нутагт үгийг номлон, тэрчлэн аян замдаа гараг.

23 Мөн дахин, миний үйлчлэгч Исаак Морли мөн миний үйлчлэгч Эзра Бут нар, явах замдаа тэрчлэн мөнхүү нутагт үгийг номлон, аян замдаа гараг.

24 Мөн дахин, миний үйлчлэгчид “Эдвард Партриж мөн Мартин Харрис нар миний үйлчлэгчид Сидней Ригдон, мөн Бага Иосеф Смит нартай хамт аян замдаа гараг.

25 Миний үйлчлэгчид Давид Витмер, Харвеи Витлок хоёр тэрчлэн аян замдаа гараг, бас мөнхүү энэ нутаг уруу явах замдаа номлог.

26 Мөн миний үйлчлэгчид “Парлей П.Пратт, ^бОорсон Пратт хоёр аян замдаа гараг,

12a Лук 22:31;
3 Ниф. 18:17–18.

13a Мат. 25:23;
С ба Г 132:53.

15a су Ёслолууд.
б су Харуусан зүрх.
в С ба Г 97:8.

17a С ба Г 66:8; 133:58.
б су Мэргэн ухаан.

18a Мат. 3:10.

19a су Ялган таних
бэлэг.

20a Мат. 8:5–13.
22a С ба Г 56:5.

су Томас Б.Марш.

24a су Эдвард
Партриж.

26a су Парлей, Пратт
Паркер.

б су Оорсон Пратт.

бас мөнхүү энэ нутаг уруу явах замдаа номлог.

27 Мөн миний үйлчлэгчид Соломон Ханкок, Симеон Картер хоёр тэрчлэн мөнхүү энэ нутаг уруу явах аян замдаа гараг, мөн замдаа номлог.

28 Миний үйлчлэгчид Эдсон Фуллер, Жекоб Скотт нар тэрчлэн аян замдаа гараг.

29 Миний үйлчлэгчид Ливай В.Ханкок, Зебедее Колтрин хоёр тэрчлэн аян замдаа гараг.

30 Миний үйлчлэгчид Рейнолдс Кахун, Самуел Х.Смит хоёр тэрчлэн аян замдаа гараг.

31 Миний үйлчлэгчид Веелер Балдвин, Виллям Картер нар тэрчлэн аян замдаа гараг.

32 Мөн миний үйлчлэгчид “Ньюел Найт, Села Ж.Гриффин хоёр хоёул томилогдог, мөн тэрчлэн аян замдаа гараг.

33 Тийм ээ, үнэнээр би хэлнэ, тэд бүгд нэг газар уруу хэдэн чиглэлээр хийх аян замдаа гараг, мөн нэг хүн нөгөөгийнхөө “суурин дээр барих, мөн нөгөөгийнхөө мөрөөр ч аялах ёсгүй.

34 Итгэлтэй тэр нь, мөнхүү тэр нь хамгаалагдан мөн их “үр жимсээр адислагдах болно.

35 Мөн дахин, би нарт хэлнэ, миний үйлчлэгчид Жозеф Веикфилд, Соломон Хамфри

хоёр дорнын нутгууд уруу аян замдаа гараг;

36 Бошиглолууд биелэгдэж болохын тулд, өөрсдийнхөө “харсан болон сонссон хамгийн баттайгаар ^битгэдэг тэдгээр зүйлүүд, бошиглогчид хийгээд төлөөлөгчдийнхөөс өөр юуг ч үл “тунхаглан, тэд гэр бүлүүдтэйгээ хөдөлмөрлөг.

37 Зөрчлийн улмаас Хеман Бассейтад хүртээсэн тэр зүйл түүнээс “авагдаж, мөн Саймондс Райдерын тэргүүн дээр байрладаг.

38 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, Жаред Картер санваартнаар “томилогдог, мөн тэрчлэн Жорж Жеймс ^бсанваартнаар томилогдог.

39 Ахлагчдын үлдсэн нь сүмүүдийг “харж хандаж байг, мөн тэдний эргэн тойрон дахь бүс нутгуудад үгийг тунхаглаг; мөн ^бхиймэл шүтээн хийгээд ёс бус явдал хэрэгжихгүй байхын тулд тэд өөрсдийн гараар хөдөлмөрлөг.

40 Мөн “ядуус хийгээд ^бгачигдагсад, өвчтөнүүд хийгээд зовж шаналагсдыг бүх зүйлд санаж байгтун, учир нь үүнийг үл хийдэг тэрээр, мөнхүү тэр нь миний шавь биш бөлгөө.

41 Мөн дахин, миний үйлч-

32а С ба Г 56:6–7.

33а Ром 15:20.

34а Иохан 15:16;

С ба Г 18:15–16.

36а Иохан 3:11.

^б су Итгэлтэй байх,

Итгэл.

^в Мозая 18:19–20;

С ба Г 52:9.

37а Мат. 25:25–30.

38а С ба Г 79:1.

^б су Санваартан,

Аароны санваар.

39а Алма 6:1.

^б су Хиймэл шүтээн.

40а С ба Г 104:15–18.

су Ядуус.

^б су Халамж.

лэгчид Бага Иосеф Смит мөн Сидней Ригдон мөн Эдвард Партриж нар сүмээс “зөвшөөрлийн бичиг биедээ авч яваг. Мөн тэрчлэн миний үйлчлэгч Оливер Каудери мөн нэгийг олж аваг.

42 Мөн ийнхүү, бүр миний хэлсэнчлэн, хэрэв та нар итгэлтэй байх аваас, эдүгээ дайсны чинь нутаг байгаа өөрсдийн чинь “өвийн нутаг болох ⁶Миссурийн нутагт

баясахаар та нар өөрсдийгөө хамтад нь цуглуулах болно.

43 Гэвч, болгоогтун, Их Эзэн бибээр хотыг тухайн цагт нь яаравчлуулах болно, мөн “баяр баяслаар мөн баясал цэнгэлээр итгэлтнүүдэд тигэм өмсгөх болно.

44 Болгоогтун, би бол Есүс Христ, Бурханы Хүү бөлгөө, мөн бибээр тэднийг эцсийн өдөр “өргөх болно. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 53

1831 оны зургадугаар сард Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Алгернон Сидней Гилбертэд өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:179–180). Сидней Гилбертийн хүсэлтээр Сүм дэх Гилберт ахын ажил хийгээд томилолтын талаар Бошиглогч Их Эзэнээс асуужээ.

1–3, Сүм дэх Сидней Гилбертийн дуудлага хийгээд сонгууль нь ахлагчаар томилогдох явдал мөн; 4–7, Тэрчлэн тэрээр бишопын төлөөний хүнээр үйлчлэх ёстой ажгуу.

БОЛГООГТУН, залбирлуудыг чинь би сонссон гэдгийг миний үйлчлэгч Сидней Гилберт чамд би хэлж байна; мөн эдгээр эцсийн өдрүүдэд Их Эзэн миний босгосон сүм дэх өөрийнхөө дуудлага хийгээд “сонгуулийн талаар Их Эзэн Бурханаас чинь чамд мэдүүлэгдэхийн тулд чи намайг дуудсан билээ.

2 Болгоогтун, дэлхийн нүглүүдийн улмаас “цовдлогдсон, Их Эзэн бибээр, чи дэлхийн зүйлүүдийг ⁶орхих ёстой хэмээх нэгэн зарлигийг чамд өгч байна.

3 Миний үгийн дагуу, итгэл хийгээд наманчлалыг мөн нүглүүдийн “ангижралыг номлохын тулд миний томилолтыг, бүр ахлагчийнхыг мөн ⁶гар тавилтаар Ариун Сүнснийг өөр дээрээ авагтун;

4 Мөн тэрчлэн үүнээс хойш өгөгдөх зарлигуудын дагуу, бишопоор томилогдох тэр газарт энэ сүмд “төлөөний хүн байгтун.

41a С ба Г 20:64.

42a С ба Г 25:2; 57:1–3.

б су Сион.

43a су Баяр баясгалан.

44a С ба Г 88:96–98.

53 1a су Дуудлага ба

Сонгогдогсод;

Сонгох;

Сонгогдогсод.

2a су Цовдлуулалт.

б су Дэлхий;

Дэлхийнх.

3a су Нүглүүдийн

ангижрал.

б су Гар тавих.

4a С ба Г 57:6, 8–10,

14–15; 84:113.

5 Мөн дахин, үнэнээр би чамд хэлнэ, чи миний үйлчлэгчид Бага Иосеф Смит, Сидней Ригдон хоёртой хамт аян замдаа гарах ёстой.

6 Болгоогтун, эдгээр нь чиний хүлээж авах анхны ёслолууд болой; мөн миний

талбай дахь хөдөлмөрийн чинь дагуу нэгэн цаг ирэхэд үлдсэн нь мэдүүлэгдэх болно.

7 Мөн дахин, зөвхөн эцсээ хүртэл “тэвчсэн тэр нь аврагддаг гэдгийг чи мэдэх ёстой хэмээнэ би. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 54

1831 оны зургадугаар сард Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Ньюел Найтад өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:180–181). Огайогийн Томпсон дахь салбарын гишүүд өмч хөрөнгийг ариулан адислахтай холбоотой асуудал дээр хуваагдсан байлаа. Амин хувиа хичээх үзэл хийгээд шунаг сэтгэл харагдсан байв, мөн өөрийн том фермийг Колесвилл, Нью-Йоркоос ирж буй Гэгээнтнүүдийн өвийн газар болгон өгөхөөр хийсэн гэрээгээ Леман Копли зөрчив. Эзра Тайре ч бас сөрөг үйл ажиллагаанд оролцов. Үүний улмаас, Ньюел Найт (Томпсон дахь салбарын ерөнхийлөгч) мөн бусад ахлагчид хэрхвэл зохихыг асуухаар Бошиглогч дээр иржээ. Бошиглогч Их Эзэнээс асууж мөн энэхүү илчлэлтийг хүлээн авчээ. (Энэ асуудлын үргэлжлэл болох хэсэг 56-г үз).

1–6, Нигүүлслийг олохын тулд Гэгээнтнүүд сайн мэдээний гэрээг сахих ёстой; 7–10, Гай зовлонд тэд тэвчээртэй байх ёстой.

БОЛГООГТУН, Их Эзэн, Бүр “Альфа ба Омега, эхлэл ба төгсгөл, бүр дэлхийн нүглүүдийн улмаас” цовдлогдсон тэрбээр ийн өгүүлнэ —

2 Болгоогтун, үнэнээр, үнэнээр, миний үйлчлэгч Ньюел Найт чамд би хэлнэ, миний томилсон тэрхүү албан тушаалд чи чанд шаргуу зогсох ёстой.

3 Мөн хэрэв ахан дүүс чинь дайснуудаасаа зайлсхийхийг хүсэх аваас, тэд бүх нүглээ наманчлаг, мөн миний өмнө чин сэтгэлээсээ “даруу төлөв хийгээд гэмшсэн байг.

4 Мөн тэд надтай хийсэн “гэрээгээ зөрчсөн учраас, бүр энэ нь “хүчингүй бөгөөд ямар ч үр нөлөөгүй болсон бөлгөө.

5 Энэхүү “нүгэл ирсэн түүнд халаг, учир нь тэрээр тэнгисийн гүнд үйж эрсэдсэн бол энэ нь түүний хувьд дээр байх байсан юм.

6 Харин гэрээг сахьж мөн зарлигийг дагасан тэд адис-

7а су Тэвчих.

54 1а Илч. 1:8;

С ба Г 19:1.

су Альфа ба Омега.

б су Цовдлуулалт.

3а су Даруу, Даруу

байдал.

4а С ба Г 42:30–39.

су Өргөл болгох,

Өргөлийн хууль.

б С ба Г 58:32–33.

5а Мат. 18:6–7.

лагдсан болой, учир нь тэд “нигүүлслийг олж авах болно.

7 Иймийн тул, дайснууд чинь та нар дээр ирэхгүйн тулд эдүгээ явж мөн уг нутаг уруу зугт; мөн аян замдаа гарагтун, мөн та нарын өмнөөс мөнгө төлөх мөн удирдагчаа болгохыг та нар хүсдэг түүнийг томилогтун.

8 Мөн ийнхүү та нар өрнөд бүс нутгууд уруу, “Миссурийн нутаг уруу, леменчүүдийн хил хязгаарууд уруу хийх аян замдаа гарах ёстой.

9 Мөн та нар аялал хийснийхээ дараа, болгоогтун, би та нарт хэлнэ, та нарт зориулсан газрыг би бэлтгэх хүртэл, хүмүүний адилаар “амьдралаа залгуулахыг та нар эрэлхийлэгтүн.

10 Мөн дахин, намайг “иртэл гай зовлонд ^бтэвчээртэй байгтун; мөн, болгоогтун, би гэнэт ирнэ; мөн миний шагнал надтай хамт байх бөлгөө, мөн намайг түрүүнд ^вэрэлхийлсэн тэд өөрсдийнхөө сүнсэнд ^аамралтыг олох болно. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 55

1831 оны зургадугаар сард Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Виллям В.Фелпст өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:184–186). Хэвлэгч Виллям В.Фелпс мөн түүний гэр бүл Көртландад дөнгөж саяхан ирээд байв, мөн Бошиглогч түүний талаарх мэдээллийг Их Эзэнээс эрэлхийлэв.

1–3, В.В.Фелпс баптисм хүртсэн байхаар, ахлагчаар томилогдохоор мөн сайн мэдээг номлохоор дуудагдаж мөн сонгогдов; 4, Тэрээр Сүмийн сургуулиудын хүүхдүүдэд зориулсан номнууд бичих ёстой; 5–6, Тэрээр өөрийн хөдөлмөрийн бүс болох Миссури уруу аялах ёстой.

БОЛГООГТУН, миний Бүйлчлэгч Виллям чамд Их Эзэн ийн хэлж байна,

тийм ээ, бүр бүхэл “дэлхийн Их Эзэн буюу, чи дуудагдсан мөн сонгогдсон болой; мөн чи усаар ^ббаптисм хүртсэний дараа хэрэв чи үүнийг миний алдар суугийн төлөө бүхнээ зориулан үйлдэх аваас чи нүглүүдээсээ ангижралыг олж мөн ^агар тавилтаар Ариун Сүнсийг хүлээж авах болно; 2 Мөн дараа нь Есүс Христ, амьд Бурханы Хүүгийн нэрээр баптисм хүртээх замаар

6а су Нигүүлсэнгүй, Нигүүлсэл.
8а С ба Г 52:42.
9а 1 Тес. 4:11.
10а Илч. 22:12.
су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.
б су Тэвчээр.
в Сур. үгс 8:17.
су Залбирал.
г Мат. 11:28–30.
су Амрах.

55 1а Дэд хууль 10:14;
1 Ниф. 11:6;
2 Ниф. 29:7.
б су Баптисм,
Баптисм хүртгээх.
в су Гар тавих.

наманчлал хийгээд нүглүүдийн “ангжралыг номлохоор, чи миний үйлчлэгч Бага Иосеф Смитийн гараар энэ сүмд ахлагч байхаар томилогдох болно.

3 Мөн чи хэн дээр ч гараа тавилаа гэсэн, хэрэв тэд миний өмнө гэмших аваас, Ариун Сүнснийг өгөх хүч чамд байх болно.

4 Мөн дахин, хэвлэх, мөн миний таалалд нийцэх зааврыг бяцхан хүүхдүүд тэрчлэн миний өмнө хүлээн авч болохын тулд энэ сүмийн сургуулиудад зориулсан “номнуудыг сонгож авах

хийгээд бичих ажлаа хийхэд нь миний үйлчлэгч Оливер Каудерид туслахаар чи томилогдох болно.

5 Мөн дахин, үнэнээр би чамд хэлнэ, энэхүү шалтгааны учир, өвийнхөө нутагт энэ ажлыг хийхээр “суурьшиж болохын тулд чи миний үйлчлэгчид Бага Иосеф Смит, Сидней Ригдон хоёртой хамт аян замдаа гарах ёстой.

6 Мөн дахин, миний үйлчлэгч Жозеф Көү тэрчлэн тэдэнтэй хамт аян замдаа гараг. Үлдсэн нь бүр миний хүслээр үүнээс хойш мэдүүлэгдэх болно. Амен.

ХЭСЭГ 56

1831 оны зургадугаар сард Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:186–188). Томас Б.Марштай хамт аялалд гарахаар томилогдсон Эзра Тайре, Маршийг (хэсэг 52:22-ыг үз) бэлэн болоход номлолоо эхлэх боломжгүй байв. Ахлагч Тайре Огайогийн Томпсон дахь асуудалд орооцолдсоны улмаас аян замд гарахад бэлэн биш байлаа (хэсэг 54-ийн толгой гарчгийг үз). Энэхүү илчлэлтийг өгснөөр уг асуудлаарх Бошиглогчийн асуултад Их Эзэн хариулжээ.

1–2, Гэгээнтнүүд авралыг олохын тулд загалмайгаа үүрч мөн Их Эзэнийг дагах ёстой; 3–13, Их Эзэн зарлиглаж мөн цуцалдаг болой, мөн дуулгаваргүйчүүд зайлуулагдах ёстой; 14–17, Ядууст үл туслах баячуудад халаг, мөн зүрх сэтгэл нь үл харуусах ядууст халаг; 18–20, Зүрх сэтгэлдээ цэвэр ариун

ядуус адислагдсан болой, учир нь тэд дэлхийг өвлөх болно.

АНХААРАГТУН, Ай та нар миний нэрийг “тунхагладаг хүмүүс, хэмээн чиний Бурхан Их Эзэн өгүүлнэ: учрыг болгоогтун, эсэргүүцэгчдэд миний уур дүрэлзэнэ, мөн үндэстнүүд дээрх

^байлчлал ба хилэгнэлийн тэрхүү өдөр миний мутар хийгээд миний зэвүүцлийг тэд мэдэх болно.

2 Мөн “загалмайгаа үл үүрч мөн намайг үл ^бдагах, мөн миний зарлигуудыг үл сахих тэрээр, мөнхүү тэрээр аврагдах нь үгүй.

3 Болгоогтун, Их Эзэн бибээр зарлиглаж байна; мөн намайг зарлиглаж мөн уг зарлиг зөрчигдсөний дараа “дуулгавартай дагаагүй тэр нь миний өөрийн тогтоосон цагт ^бтусгаарлагдах болно.

4 Иймийн тул, Их Эзэн бибээр надад сайн санагдсанаар зарлигладаг мөн “цуцалдаг буюу; мөн энэ бүгд нь ^бэсэргүүцэгчдийн толгой дээр хариулагдах хэмээн Их Эзэн хэлдэг бөлгөө

5 Иймийн тул, бибээр өөрийн үйлчлэгчид “Томас Б.Марш, Эзра Тайре хоёрт өгсөн зарлигаа цуцалж мөн Миссури нутаг уруу явах аян замдаа үтэр түргэн гар хэмээх шинэ зарлигийг би өөрийн үйлчлэгч Томаст өгч байна, мөн миний үйлчлэгч Села Ж.Гриффин тэрчлэн түүнтэй хамт явах болно.

6 Учрыг болгоогтун, Томпсонд байгаа өөрийн хүмүүсийн зөрүүдлэл, мөн тэдний эсэргүүцлүүдийн улмаас

бибээр өөрийн үйлчлэгчид Села Ж.Гриффин, Ньюел Найт хоёрт өгсөн зарлигаа цуцалж байна.

7 Иймийн тул, миний үйлчлэгч Ньюел Найт тэдэнтэй хамт үлдэг; мөн миний өмнө гэмшдэг болгон нь явахыг хүсвэл явж болно, мөн миний томилсон нутаг уруу түүгээр удирдагдаг.

8 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, миний үйлчлэгч Эзра Тайре өөрийн “бардамнал хийгээд амин хувиа хичээсэн үзлээ наманчлах, мөн амьдардаг газрынх нь талаар түүнд миний өгсөн хуучин зарлигийг дуулгавартай дагах ёстой.

9 Мөн хэрэв тэр үүнийг хийх аваас, тэрээр Миссурийн нутаг уруу явахаар томилогдсон хэвээр байх болно, учир нь уг нутагт ямар ч хуваагдал байх ёсгүй;

10 Эс бөгөөс тэрээр өөрийнхөө төлсөн мөнгийг хүлээж авах ёстой, мөн уг газрыг орхин явах ёстой, мөн миний сүмээс “тусгаарлагдах ёстой хэмээн түмний Бурхан Их Эзэн хэлж байна;

11 Мөн тэнгэр хийгээд дэлхий “алга болох хэдий ч, эдгээр үгс алга болох нь үгүй; харин биелэгдэх болно.

12 Мөн хэрэв миний үйлч-

16 Иса. 10:3–4;
Морм. 9:2;
С ба Г 1:13–14;
124:10.

2a Лук 14:27.

б 1 Петр 2:21;
2 Ниф. 31:10–13;
Моро. 7:11.

сү Есүс Христ—
Есүс Христийн
үлгэр жишээ.
3a сү Дуулгавартай
байх, Дуулгавар-
тай, Дуулгавартай
дагах.
б С ба Г 1:14–16; 50:8.

4a С ба Г 58:31–33.
б сү Эсэргүүцэл.
5a сү Томас Б.Марш.
8a сү Бардамнал.
10a сү Сүмээс хөөх.
11a 2 Ниф. 9:16.

лэгч Бага Иосеф Смит уг мөнгийг төлөх ёстой нь шаардлагатай аваас, болгоогтун, түүний хүлээн авах тэд хийснийхээ дагуу эргэн шагнагдаж болохын тулд Их Эзэн бибээр Миссурийн нутагт үүнийг түүнд дахин төлөх болно;

13 Тэд хийснийхээ дагуу, бүр өвийнхөө нутгийг хүлээн авах болно.

14 Болгоогтун, Их Эзэн өөрийн хүмүүст ийн хэлнэ— та нарт хийх мөн наманчлах зүйлүүд олон буй; учрыг болгоогтун, та нарын нүглүүд надад ирээд байна, мөн та нар “зөвлөгөөг өөрсдийнхөө арга замуудаар эрэлхийлдэг учраас өршөөгдөх нь үгүй бөлгөө.

15 Мөн та нарын зүрх сэтгэл үл ханана. Мөн та нар үнэнийг дуулгавартай дагах нь үгүй, харин зөв шударга бус байдалд “баяр хөөртэй байдаг.

16 Эд хөрөнгөө “ядууст үл өгөгч “баян хүмүүс та нарт халаг, учир нь та нарын “баялагууд бодгалиудыг чинь ялзруулах болно; мөн энэ нь айлчлалын мөн шүүлтийн мөн зэвүүцлийн өдөр та

нарын гашуудал байх болно: “Ургац өнгөрч, зун дуусчээ, мөн миний сүнс аврагдсан нь үгүй!

17 Зүрх сэтгэл нь харуусдаггүй, сүнс нь гэмшдэггүй, мөн гэдэс нь цаддаггүй, бас гараа бусад хүмүүсийн эд юмс дээр тавихаас буцдаггүй, нүд нь “шуналаар дүүрэн, мөн өөрийнхөө гараар хөдөлмөрлөдөггүй “ядуу хүмүүс та нарт халаг!

18 Харин зүрх сэтгэлдээ цэвэр ариун, зүрх сэтгэл нь “харуусдаг, сүнс нь гэмшдэг “ядуус адислагдсан болой, учир нь тэднийг чөлөөлөхөөр Бурханы “хаант улс хүч хийгээд агуу алдар суунд ирэхийг тэд үзэх болно; учир нь “дэлхийн сайн зүйлүүд тэднийх байх болно.

19 Учрыг болгоогтун, Их Эзэн ирэх болно, мөн түүний “төлөөс түүнтэй хамт байх болно, мөн тэрээр хүн болгоныг шагнах болно, мөн ядуус баясах болно;

20 Мөн тэдний үеийнхэн дэлхийг нэг үеэс нөгөө үед үүрд болон мөнхөд “өвлөх болно. Мөн эдүгээ бибээр та нарт ярихаа төгсгөл болгоё. Бүр тийм буюу. Амен.

14a Иаков 4:10.

15a Алма 41:10;

3 Ниф. 27:11.

16a Сур. үгс 14:31;

Алма 5:55–56.

су Ядуус.

б су Өглөг, Өглөг өгөх.

в Иер. 17:11;

2 Ниф. 9:30.

г Иаков 5:3.

д Иер. 8:20;

Алма 34:33–35;

С ба Г 45:2.

17a су Шунах.

б Мозая 4:24–27;

С ба Г 42:42;

68:30–32.

18a су Харууссан зүрх.

б Мат. 5:3, 8; Лук 6:20;

3 Ниф. 12:3.

су Ядуус.

в су Бурханы хаант

улс буюу Тэнгэрийн хаант улс.

г су Газар дэлхий.

19a Илч. 22:12;

С ба Г 1:10.

20a Мат. 5:5;

С ба Г 45:56–58.

ХЭСЭГ 57

1831 оны долдугаар сарын 20-нд Миссурийн Жаксон гүнлэгийн, Сионд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:189-190). Ахлагчид Их Эзэний зарлигийг (хэсэг 52) даган мөрдөж, Көртландаас олон янзын үйл явдал мөн зарим эсэргүүцэлтэй тулгаран Миссури уруу аялжээ. Леменчүүдийн байдал хийгээд соёл иргэншлийн дутмаг байдал, сайжруулалт мөн хүмүүсийн дундах шашныг Бошиглогч ерөнхийд нь бясалган бодоод: “Аглаг буйд хэдийд сарнай лугаа адил цэцэглэх вэ? Сион алдар суундаа хэзээ баригдаж мөн эцсийн өдрүүдэд бүх үндэстнүүд түүн уруу ирэх Таны ариун сүм хаана сүндэрлэн босох вэ?” хэмээн өгүүлжээ (History of the Church, 1:189). Тэгээд тэрээр энэхүү илчлэлтийг хүлээн авсан ажээ.

1-3, Миссурийн Индепенденс бол Сионы Хот хийгээд ариун сүмд зориулсан газар мөн; 4-7, Гэгээнтнүүд тэр бүст газар худалдаж аван мөн өв хөрөнгө хүлээж авах ёстой 8-16, Сидней Гилберт дэлгүүр нээх ёстой, В.В.Фелпс хэвлэгч байх ёстой, мөн Оливер Каудери нийтлэлийн учир материалыг хянан тохиолдуулах ёстой.

АНХААРАГТУН, “Миссурийн нутаг болох, гэгээнтнүүдийн ^бцугларалтын тулд бибээр та нарт өгсөн мөн ^аариулан адисласан нутаг болох, энэ нутагт, миний зарлигуудын дагуу өөрсдийгөө хамтад нь цуглуулаад байгаа, Ай миний сүмийн ахлагчид та нар хэмээн та нарын Бурхан Их Эзэн хэлж байна.

2 Иймийн тул, энэ бол амлалтын нутаг, мөн “Сион хотод зориулсан ^бгазар бөлгөө.

3 Мөн та нарын Бурхан Их Эзэн ийн хэлдэг, хэрэв та нар мэргэн ухааныг хүлээн авбаас, энэ нь мэргэн ухаан болой. Болгоогтун, эдүгээ Индепенденс хэмээн нэрлэгдэх уг газар нь төв газар болой; мөн “ариун сүмд зориулсан хэсэг газар нь баруунтаа, шүүхийн байрнаас холгүй газарт буй.

4 Иймийн тул, уг нутаг, мөн тэрчлэн өрнөд уруу чиглэсэн газар болгон нь, яг “Иудей хийгээд харийн хоорондох бүр хилийн зааг хүртэлх тэр газар нь гэгээнтнүүдээр ^бхудалдан авагдах ёстой нь мэргэн ухаан юм;

5 Мөн тэрчлэн миний шавь нар газар “худалдан авах бо-

57 1а С ба Г 52:42.
 б су Израил—
 Израилын
 цугларалт.
 в С ба Г 61:17.
 г С ба Г 29:7-8;
 45:64-66.

2а су Сион.
 б С ба Г 28:9; 42:9, 62.
 3а С ба Г 58:57;
 97:15-17.
 4а өх “Иудей” гэдэг нь
 леменчүүд,
 “харийнхан” гэдэг

нь цагаан арьстан
 суурьшигчдыг
 хэлж байна.
 б С ба Г 48:4.
 5а С ба Г 58:49, 51;
 101:68-74.

ломжтой байхын хэрээр хээр тал нутагтай хил залгаж буй газар бүрийг буюу. Болгоогтун, тэд үүнийг үүрдийн өв болгон ⁶олж авч болохын тулд, энэ нь мэргэн ухаан юм.

6 Мөн миний үйлчлэгч Сидней Гилберт, зөв шударга байдалд хийгдэж болохын хэрээр, мөн мэргэн ухаан чиглүүлэхийн хэрээр мөнгө хүлээн авахын тулд, сүмд “төлөөний хүн байхын тулд, эргэн тойрны бүх бүс нутагт газар худалдаж авахын тулд тэрээр миний томилсон албан тушаалд үүргээ биелүүлэг.

7 Мөн миний үйлчлэгч “Эдвард Партриж өөрийг нь миний томилсон албан тушаалд үүргээ биелүүлэг, мөн гэгээнтнүүдэд бүр миний зарлигласнаар өөрсдийнх нь өв хөрөнгийг ⁶хувааг; мөн тэрчлэн өөрт нь туслахын тулд түүний томилсон тэд ч мөн адил буюу.

8 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлнэ, миний үйлчлэгч Сидней Гилберт өөрийгөө энэ газарт суурьшуулаг, тэрээр эд барааг заль мэхгүйгээр зарж болохын тулд, тэрээр гэгээнтнүүдийн сайн сайхны төлөө газар худалдаж авах мөнгө олж авч болохын тулд, түүнчлэн өөрсдийгөө өвөндөө суурьшуулахын тулд шавь нарт хэрэгтэй байж

болох аливаа зүйлүүдийг тэрээр олж авч болохын тулд мөн дэлгүүр нээг.

9 Мөн тэрчлэн миний үйлчлэгч Сидней Гилберт, тэрээр тэрчлэн эд барааг хүмүүст, бүр тэрээр өөрийн үйлчлэлд бичиг хэргийн ажилтнаар ажиллуулахаар хүссэн тэднээр илгээж болохын тулд зөвшөөрөл олж аваг—болгоогтун энэ нь мэргэн ухаан болой,—мөн уншдаг хэн ч гэсэн тэрээр ойлгог;

10 Мөн, “харанхуйд мөн уг бүс нутагт бас үхлийн ⁶сүүдэрт суугаа тэдэнд миний сайн мэдээ номлогдож болохын тулд ийнхүү миний гэгээнтнүүдийг хангаж болох бөлгөө.

11 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлнэ, миний үйлчлэгч “Виллям В.Фелпс энэ газарт суурьшуулагдаг, мөн сүмд ⁶хэвлэгч болгогдог.

12 Мөн харагтун, хэрэв дэлхий түүний бичээсүүдийг хүлээн авбаас—болгоогтун энэ нь мэргэн ухаан болой—гэгээнтнүүдийн сайн сайхны төлөө, зөв шударга байдалд тэрээр олж авч чадах юуг ч болов тэрээр олж аваг.

13 Мөн бүх зүйл миний өмнө зөв байж болохын тулд мөн түүгээр дамжин Сүнсээр энэ нь нотлогдохын тулд миний үйлчлэгч “Оливер Каудери хуулах мөн залруулах, мөн

5б С ба Г 56:20.

6а С ба Г 53.

7а С ба Г 58:24.

су Эдвард
Партриж.

б С ба Г 41:9–11;

58:14–18.

10а Иса. 9:2; Мат. 4:16.

су Сүнсний
харанхуй.

б Дуул. 23:4.

11а су Виллям В.Фелпс.

б С ба Г 58:37, 40–41.

13а су Оливер
Каудери.

сонгож авах ямар ч салбарт би түүнийг томилсон бай, бүр миний зарлигласны дагуу түүнд туслаг.

14 Мөн ийнхүү миний ярьсан тэд, бүр тэдгээр зүйлүүдийг бүр миний ярьсны дагуу хийхийн тулд Сионы нутагт гэр бүлүүдийнхээ хамт аль болох түргэнээр суурьшигдаг.

15 Мөн эдүгээ уг цугларал-

тын талаар — Энэ нутаг уруу явахаар зарлигдуулсан тэдгээр гэр бүлүүдийн бэлтгэлийг бишоп болон төлөөний хүн аль болохоор түргэн хангаг, мөн тэднийг өөрсдийнх нь өвд суурьшуулаг.

16 Мөн ахлагчид хийгээд гишүүд аль алиных нь үлдсэнд нь цаашдын чиглэлүүд үүнээс хойш өгөгдөх болно. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 58

1831 оны Наймдугаар сарын 1-нд Миссурийн Жаксон гүнлэгийн, Сионд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:190–195). Бошиглогч хийгээд түүний бүлэг хүмүүс Миссурийн Жаксон гүнлэгт ирсний дараах анхны Хүндэтгэлийн өдөр шашны үйлчлэл болж, мөн хоёр гишүүн баптисмаар хүлээн авагджээ. Тэр долоо хоногийн турш Томпсон Салбараас Колесвиллийн зарим Гэгээнтнүүд мөн бусад хүмүүс иржээ (хэсэг 54-ийг үз). Олон нь цугларалтын шинэ газар дахь өөрсдийнхөө талаарх Их Эзэний тааллыг мэдэхийг эгээрэн хүсч байлаа.

1–5, Гай зовлонг тэвчсэн тэд алдар суугийн титэм өмсөх болно; 6–12, Гэгээнтнүүд Хурганы гэрлэлт хийгээд Их Эзэний үдшийн зоогт бэлтгэх ёстой; 13–18, Бишопууд бол Израилын шүүгчид мөн; 19–23, Гэгээнтнүүд тухайн нутгийн хуулиудыг дуулавартай дагах ёстой; 24–29, Хүмүүс сайныг үйлдэхийн тулд сонгох эрхээ ашиглах ёстой; 30–33, Их Эзэн зарлигладаг мөн цуцалдаг; 34–43, Наманчлахын тулд, хүмүүс нүглүүдээ хүлээж мөн орхих ёстой; 44–58, Гэгээнтнүүд өөрсдийн өвийг худалдан авч мөн Миссурид цугларах ёстой;

59–65, Сайн мэдээ хүн болгонд номлогдох ёстой.

АНХААРАГТУН, Ай миний Асүмийн ахлагчид мөн миний үгэнд чих тавигтун, мөн та нарын талаар, мөн тэрчлэн бибээр та нарыг илгээсэн энэ “нутгийн талаар миний юу хүсдэгийг надаас мэдэж авагтун.

2 Учир нь үнэнээр би та нарт хэлнэ, миний зарлигуудыг “сахьдаг тэрээр амьддаа ч мөн ^бүхэлд ч адислагдсан болой; мөн ^вгай зовлон тохиолдоход ^гитгэлтэй байдаг түүний, мөнхүү түүний шагнал нь

58 1а С ба Г 57:1–8.
2а Мозая 2:22.

б 1 Петр 4:6.
в су Дайсан.

г 2 Тес. 1:4.

тэнгэрийн хаант улсад илүү агуу бөлгөө.

3 Үүнээс хойш тохиох тэдгээр зүйлүүдийн талаарх “Бурханыхаа төлөвлөгөөг, мөн их гай зовлонгийн дараа дагалдах ⁶алдар сууг энэ үед та нар эгэл нүдээрээ болгоож чадах нь үгүй.

4 Учир нь их “гай зовлонгийн дараа ⁶адислалууд ирдэг болой. Иймийн тул та нар их ⁶алдар суугийн ⁷титэм өмсөх тэрхүү өдөр ирнэ; цаг нь хараахан болоогүй ч, ойрхон байна.

5 Та нар үүнийг зүрх сэтгэлдээ “тавьж, мөн дагалдан ирэх тэрхүү зүйлийг хүлээн авч болохын тулд та нарт өмнө нь миний ярьсныг санагтун.

6 Болгоогтун, үнэнээр би та нарт хэлнэ, та нар дуулгавартай байж болохын тулд, мөн ирэх тэрхүү зүйлүүдийн тухай ⁶гэрчлэхэд зүрх сэтгэл чинь ⁶бэлтгэгдэж болохын тулд — энэхүү шалтгааны учир бибээр та нарыг илгээсэн бөлгөө;

7 Мөн тэрчлэн та нар суурийг тавихаар, мөн дээр нь Бурханы “Сион сүндэрлэн босох тэрхүү нутгийн талаар гэрчлэхээр хүндэтгэл хүлээж болохын тулд;

8 Мөн тэрчлэн сайн зүйлүүдийн найр “ядуусын төлөө бэлтгэгдэж болохын тулд; тийм ээ, бошиглогчдын үгс биелэгдэхгүй байх нь үгүйг дэлхий мэдэж болохын тулд сайн зүйлүүдийн, нэн сайн цэвэршүүлсэн ⁶тунгаамал дарсны найр буюу;

9 Тийм ээ, бүх үндэстнүүд үүнд уригдах сайн бэлтгэгдсэн Их Эзэний өргөөний үдшийн зоог болой.

10 Нэгдүгээрт, баячууд хийгээд эрдэм боловсролтойчууд, мэргэн ухаантнууд хийгээд язгууртнууд;

11 Мөн түүний дараа миний сүр хүчний өдөр ирэх бөлгөө; тэгээд ядуус, хазгар доголлончууд, мөн хараагүйчүүд, бас дүлийчүүд, Хурганы “гэрлэлтэд ирж мөн ирэх тэрхүү агуу өдөрт бэлтгэсэн Их Эзэний ⁶үдшийн зоогноос хүртэх болно.

12 Болгоогтун, Их Эзэн, бибээр үүнийг ярилаа.

13 Мөн “гэрчлэл нь Сионоос, тийм ээ, Бурханы өвийн хотын амнаас урагш одож болохын тулд —

14 Тийм ээ, энэ шалтгааны улмаас бибээр та нарыг ийш нь илгээж, мөн өөрийн үйлчлэгч “Эдвард Партрижийг сонгон авч, мөн энэ нутаг

3a су Бурхан, Бурхан тэргүүтэн.

б су Алдар суу.

4a Дуул. 30:5;

С ба Г 101:2–7;
103:11–14; 109:76.

б су Адислах,
Адислагдах,
Адислал.

в Ром 8:17–18;

С ба Г 136:31.

г су Титэм;

Өргөмжлөл.

5a Дэд хууль 11:18–19.

6a су Гэрчлэл.

б С ба Г 29:8.

7a су Сион.

8a су Ядуус.

б Иса. 25:6.

11a Мат. 22:1–14;

Илч. 19:9;

С ба Г 65:3.

б Лук 14:16–24.

13a Мика 4:2.

14a су Эдвард
Партриж.

дахь ажил үүргийг нь түүнд томилсон билээ.

15 Гэвч итгэлгүй хийгээд зүрх сэтгэл нь харалган байгаа тэрхүү нүглүүдээ тэрээр эс наманчлах аваас, тэрээр “унахгүйн тулд анхаараг.

16 Болгоогтун ажил үүрэг нь түүнд өгөгдсөн болой, мөн энэ нь дахин өгөгдөх нь үгүй.

17 Мөн энэ үүрэг даалгаварыг биелүүлэх хэн боловч, Бурханы өвийн нутгуудыг түүний “хүүхдүүдэд хуваахын тулд энэ нь эрт дээр үед байсны адилаар Израилын ⁶шүүгч байхаар томилогддог бөлгөө;

18 Мөн Бурханы “бошиглогчдоор өгөгддөг хаант улсын хуулиудын дагуу, үнэнч шударга хүмүүсийн гэрчлэлээр, мөн зөвлөхүүдийнхээ туслалцаатайгаар, түүний хүмүүсийг шүүхээр буюу.

19 Учир нь үнэнээр би та нарт хэлнэ, миний хууль энэ нутагт сахигдах ёстой.

20 Өөрийгөө захирагч хэмээн хэн ч үл бодог; гэвч шүүдэг түүнийг, эсвээс өөр үгээр, зөвлөгөө өгөгч буюу шүүгчийн суудал дээр суугч түүнийг Бурхан тааллынхаа зөвлөгөөний дагуу захираг.

21 Уг нутгийн хуулиудыг хэн ч үл зөрчиг, учир нь Бурханы хуулиудыг сахьдаг тэрээр уг

нутгийн “хуулиудыг зөрчих шаардлагагүй билээ.

22 Иймийн тул, эрх нь хаанчлах явдал болох түүнийг “хаанчилж, мөн бүх дайснуудыг хөл дороо захирах хүртэл байх ёстой хүчнүүдэд захирагдагтун.

23 Болгоогтун, миний гараас та нарын хүлээж авсан “хуулиуд бол сүмийн хуулиуд мөн, энэ гэрэлд та нар тэднийг урагш өргөж явах ёстой. Болгоогтун, энэ нь мэргэн ухаан болой.

24 Мөн эдүгээ, бибээр өөрийн үйлчлэгч Эдвард Партрижийн талаар хэлсэнчлэн, энэ нутаг бол түүний, мөн тэрчлэн өөрийн зөвлөхүүдээр түүний томилсон тэдний оршин суух нутаг болой; мөн тэрчлэн “агуулахыг минь ажиллуулахаар миний томилсон түүний оршин суух нутаг буюу;

25 Иймийн тул, тэд өөр хоорондоо хийгээд надтай зөвлөлдөн гэр бүлүүдээ энэ нутагт авчраг.

26 Учрыг болгоогтун, бүх зүйлд би зарлиглах нь тохирохгүй бөлгөө; учир нь бүх зүйлд албадуулдаг тэр нь “лазан хийгээд ухаалаг биш үйлчлэгч лугаа адил юм; иймийн тул, тэрээр шагнал хүлээж авах нь үгүй.

27 Үнэнээр би хэлнэ, хүмүүс

15a 1 Кор. 10:12.

17a су Бурханы хөвгүүд охид.

б С ба Г 107:72–74.

су Бишоп.

18a су Бошиглогч.

21a Лук 20:22–26;

С ба Г 98:4–10;

ИТ 1:12.

су Засгийн газар.

22a су Есүс Христ;

Мессиа;

Мянган жил.

23a су Хууль.

24a С ба Г 51:13; 70:7–11.

26a Мат. 24:45–51;

С ба Г 107:99–100.

сайн зарчимд “санаа сэтгэлээ бүрэн зориулж, мөн чөлөөт хүсэл зоригоороо олон зүйлийг хийж, мөн туйлын зөв шударга байдлыг тохиолгохоор авчрах ёстой;

28 Учир нь хүч тэдэнд буй, үүгээр тэд өөрсдийнхөө төлөө “сонгогчид юм. Мөн хүмүүс сайныг үйлдэхийн хэрээр тэд яавч шагналаа алдах учиргүй.

29 Гэвч түүнд зарлиглах хүртэл юу ч хийдэггүй, мөн зарлигийг зүрх сэтгэлийн эргэлзээтэйгээр хүлээн авдаг, мөн үүнийг залхуугаар сахьдаг тэр нь, мөнхүү тэр нь “яллагддаг бөлгөө.

30 Хүмүүнийг “бүтээгээд, зарлигуудыг минь үл дагагч түүнийг гэмгүйгээр байлгах бибээр хэн билээ хэмээн Их Эзэн хэлдэг.

31 “Амлаад мөн биелүүлээгүй бибээр хэн бэ? хэмээн Их Эзэн хэлдэг.

32 Бибээр зарлигладаг мөн хүмүүн дуулгавартай дагадаггүй билээ; бибээр “цуцалдаг мөн тэд адислал хүлээн авдаггүй.

33 Тэгээд тэд зүрх сэтгэлдээ өгүүлдэг: Энэ бол Их Эзэний ажил биш, учир нь түүний амлалтууд биелэгдсэнгүй. Харин иймүүдэд нь халаг, учир нь тэдний шагнал “доороос отоож буй мөн дээрээс бус авай.

34 Мөн эдүгээ энэ нутгийн талаарх цаашдын чиглэлүүдийг би та нарт өгч байна.

35 Миний үйлчлэгч Мартин Харрис, мөнгөө сүмийн бишопын өмнө “тавьснаар сүмд үлгэр дууриал болох нь надад орших мэргэн ухаан болой.

36 Мөн тэрчлэн, энэ нь өв хүлээн авахаар энэ нутагт ирэх хүн болгонд хууль бөлгөө; мөн хууль чиглүүлдгийн дагуу тэрээр мөнгөө эрхлэн зарцуулах ёстой.

37 Мөн тэрчлэн агуулах, мөн тэрчлэн “хэвлэх үйлдвэрийн газар байхын тулд Индепенденст газрууд худалдан авагдах ёстой нь мэргэн ухаан болой.

38 Мөн түүнд сайн санагдснаар өөрийн өвийг хүлээн авч болохын тулд миний үйлчлэгч Мартин Харрист холбогдох бусад зааврууд түүнд Сүнсээр өгөгдөх болно;

39 Мөн тэрээр нүглүүдээ наманчлаг, учир нь тэрээр дэлхийн “магтаалыг эрэлхийлдэг болой.

40 Мөн тэрчлэн миний үйлчлэгч “Виллям В.Фелпс өөрийг нь миний томилсон тэрхүү албан тушаалд үүргээ биелүүлэг, мөн уг нутагт өөрийн өвийг хүлээн аваг;

41 Мөн тэрчлэн тэрээр наманчлах хэрэгтэй, учир нь Их Эзэн, миний таалалд тэрээр үл нийцнэм, учир нь

27a су Хичээл зүтгэл;

Ажлууд.

28a су Сонгох эрх.

29a су Ял.

30a Иса. 45:9–10;

Хил. 12:6.

31a С ба Г 1:37–38; 82:10.

32a С ба Г 56:3–4.

33a С ба Г 29:45.

35a С ба Г 42:30–32.

37a С ба Г 57:11–12.

39a 2 Ниф. 26:29;

С ба Г 121:34–37.

40a су Виллям В.Фелпс.

тэрээр давамгайлахыг эрэлхийлдэг бөлгөө, мөн тэрээр миний өмнө хангалттай номхон дөлгөөн биш байна.

42 Болгоогтун, нүглүүдээ “наманчилсан тэрээр, мөнхүү тэр нь ^бөршөөгддөг ажгуу, мөн Их Эзэн, бибээр тэдгээрийг нь цаашид ^асанах нь үгүй.

43 Хүн нүглүүдээ наманчилдаг эсэхийг та нар үүгээр нь мэдэж болно — болгоогтун, тэрээр тэдгээрийг ^ахүлээж мөн ^борхих болно.

44 Мөн эдүгээ, үнэнээр би өөрийн сүмийн үлдсэн ахлагчдын талаар хэлье, энэ нутагт өөрсдийн өвийг хүлээн авах тэр цаг хараахан ирээгүй байна, тэд үүнийг итгэлийн залбирлаар дамжуулан хүсэхээс бусдаар гагцхүү энэ нь тэдэнд Их Эзэнээс өгөгдөхөөс бусдаар тэдний хувьд олон жил болох вий.

45 Учир нь, болгоогтун, тэд дэлхийн хязгааруудаас хүмүүсийг хамтад нь ^атүрэх болно.

46 Иймийн тул, өөрсдийгөө хамтад нь цуглуулагтун; мөн энэ нутагт үлдэхээр томилогдоогүй тэд эргэн тойрны бүс нутгуудад сайн мэдээг номлог; мөн түүний дараа тэд гэр орондоо эргэж ирэг.

47 Замдаа тэд номлог, мөн бүх газарт үнэнийг ^агэрчлэн, мөн баячууд, дээдэс хийгээд

дорд борчууд, мөн ядуусыг наманчлахад дуудаг.

48 Мөн дэлхийн оршин суугчид наманчлахын хэрээр, тэд ^асүмүүдийг байгуулаг.

49 Мөн “Сионд газрууд худалдаж авах мөнгө хүлээн авахаар Огайо дахь сүмд сүмийн дуу хоолойгоор томилогдсон төлөөний хүн байг.

50 Мөн, Сионы нутгийн тодорхойлолт хийгээд Бурханы тааллын тунхаглалыг энэ нь Сүнсээр түүнд мэдүүлэгдсэнээр тэрээр ^абичих ёстой хэмээх зарлигийг би өөрийн үйлчлэгч Сидней Ригдонд өгч байна;

51 Мөн мөнгө олж авахын тулд, бишопт өөрт нь буюу төлөөнийх нь хүний гарт тавигдахын тулд түүнд сайн санагдсанаар, эсвээс түүний чиглүүлснээр Бурханы хүүхдүүдийн өв болгож газруудыг худалдаж авахын тулд захидал болон хандивын баримт бүх сүмд хүргэгдэх ёстой.

52 Учир нь, болгоогтун, үнэнээр би та нарт хэлнэ, бүр улс орны энэ бүс нутгийг цаг нь болоход аль болох түргэнээр бүхэлд нь худалдаж авахын тулд шавь нар хийгээд хүмүүний үрс зүрх сэтгэлээ нээх ёстойг Их Эзэн хүсч байна.

53 Болгоогтун, энэ нь мэргэн ухаан болой. Тэд үүнийг

42a су Наманчлах, Наманчлал.
б Иса. 1:18.
су Уучлах.
в Иса. 43:25.
43a С ба Г 19:20; 64:7.
су Хүлээн

зөвшөөрөх, Хүлээн зөвшөөрөлт.
б С ба Г 82:7.
45a Дэд хууль 33:17.
су Израил—
Израилын
цугларалт.

47a С ба Г 68:8.
48a ө.х. Сүмийн
салбарууд.
49a су Сион.
50a С ба Г 63:55–56.

хийг, эс тэгвээс цус урсгалтаас өөрөөр тэд “өвийг хүлээн авах нь үгүй.

54 Мөн дахин, газар олж авагдахын хэрээр, Бурханы гэгээнтнүүдийн төлөө хөдөлмөрлөхийн тулд бүхий л төрлийн ажилчид энэ нутаг уруу урагш илгээгдэг.

55 Эдгээр бүх зүйл эмх цэгцэд хийгдэг; мөн уг нутгуудын ажлын боломжууд бишоп буюу сүмийн төлөөний хүнээр үе үе мэдүүлэгдэж байг.

56 Мөн цугларалтын ажил нь яаруу тэвдүүд ч, тэрчлэн зугталтад ч бүү байг; харин чуулганууд дээр сүмийн ахлагчдаар зөвлөлдсөнөөр, тэдний үе үе хүлээн авдаг мэдлэгийн дагуу энэ нь хийгдэг.

57 Мөн миний үйлчлэгч Сидней Ригдон энэ нутгийг мөн “ариун сүмийн газрыг Их Эзэнд ариулж мөн онцгойлон адислаг.

58 Мөн чуулганы хуралдаан зарлагдаг; мөн үүний дараа миний үйлчлэгчид Сидней Ригдон мөн Бага Иосеф Смит, мөн тэрчлэн тэдэнтэй хамт Оливер Каудери, тэд өөрсдийнхөө нутагт, тэдэнд миний томилсон ажлын үлдсэнийг нь биелүүлэхийн тулд эргэж ирэг, мөн үлдсэн ажил нь чуулгануудаар “чиглүүлэгдэх болно.

59 Мэддэг, мөн хамгийн

баттай итгэдэг тэрхүү зүйлийнхээ талаар замдаа “гэрчлэхгүйгээр хэн ч энэ нутгаас эргэж бүү яваг.

60 Зиба Петерсонд хүртээгдсэн тэрхүү зүйл нь түүнээс авагдаг; мөн бүхий л нүглүүдийнхээ төлөө хангалттай “даруусгагдах хүртлээ тэрээр сүмд гишүүний үүргээ биелүүлэг, мөн өөрийнхөө гараар, ахан дүүстэй хамт хөдөлмөрлөг; учир нь тэрээр нүглүүдээ хүлээдэггүй, мөн тэрээр тэдгээрийг нуухыг боддог билээ.

61 Энэ нутагт ирж буй, зарим нь бүр хэмжээлшгүй ихээр адислагдсан энэ сүмийн ахлагчдын үлдсэн нь, тэрчлэн энэ нутаг дээр чуулганыг зохион байгуулаг.

62 Мөн миний үйлчлэгч Эдвард Партриж тэднээр зохион байгуулагдах уг чуулганыг чиглүүлэг.

63 Мөн тэд тэрчлэн сайн мэдээг замдаа номлон, өөрсдөдөө илчлэгдсэн зүйлүүдийн талаар гэрчлэн, эргэж ирэг.

64 Учир нь, үнэнээр, уг дуу хоолой энэ газраас бүх дэлхийд, мөн дэлхийн хязгааруудад очиж сайн мэдээг хүн болгонд, итгэгч тэднийг дагалддаг “тэмдгүүдийн хамт ^бномлогдох ёстой.

65 Мөн болгоогтун Хүний Хүү “ирэх болно. Амен.

53a С ба Г 63:27–31.

57a С ба Г 57:3; 84:3–5, 31; 97:10–17.

58a су Нийтийн

дэмжлэг.

59a су Гэрчлэл.

60a су Зэмлэх, Зэмлэл.

64a су Тэмдэг.

б су Номлох.

65a су Есүс Христийн Хоёр дахь Ирэлт.

ХЭСЭГ 59

1831 оны наймдугаар сарын 7-нд Миссурийн Жаксон гүнлэгийн, Сионд, Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:196-201). Бошиглогч энэ илчлэлтийн цэдгийн өмнөх үг болгон, тэгэхэд хүмүүс цугласан байсан Сионы нутгийн талаар тодорхой бичжээ. Их Эзэний чиглүүлснээр уг нутаг ариулан адислагдсан байв, мөн ирээдүйн ариун сүм баригдах газар онцгойлон адислагдсан ажээ. Их Эзэн эдгээр зарлигуудыг Сион дахь Гэгээнтнүүдэд зориулж тусгайлан өгчээ.

1-4, Сион дахь итгэл бүхий Гэгээнтнүүд адислагдах болно; 5-8, Тэд Их Эзэнийг хайрлаж мөн үйлчлэн мөн түүний зарлигуудыг сахих ёстой; 9-19, Их Эзэний өдрийг ариунаар нь сахьснаар, Гэгээнтнүүд эд материалын хийгээд сүнслэг байдлаар адислагдах болно; 20-24, Зөв шударгыг үйлдэгчдэд энэ дэлхийд амар амгалан мөн ирэх дэлхийд мөнх амьдрал амлагджээ.

БОЛГООГТУН, миний зарлигуудын дагуу, миний алдар суугийн төлөө бүхнээ “зориулахаар энэ нутагт ирсэн тэд адислагдсан болой хэмээн Их Эзэн хэлэв.

2 Учир нь амьдарч буй тэд дэлхийг “өвлөх болно, мөн ^бнас нөгчих тэд бүхий л хөдөлмөрүүдээсээ амрах болно, мөн ажлууд нь тэднийг дагалдах болно; бас тэд өөрс-

дод нь зориулан миний бэлтгэсэн Эцэгийн минь “харшуудад ‘титэм хүлээн авах болно.

3 Тийм ээ, миний сайн мэдээг дуулгавартай дагаж, Сионы нутаг дээр хөл тавьсан тэд адислагдсан бөлгөө; учир нь тэд өөрсдийнхөө шагналд дэлхийн сайн зүйлүүдийг хүлээн авна, мөн энэ нь “хүч чадлаа урагш авчрах болно.

4 Мөн тэрчлэн миний өмнө “итгэлтэй хийгээд ^бхичээнгүй тэд—тэд дээрээс ирэх адислалуудаар, тийм ээ, цөөн бус зарлигуудаар, мөн тохирох цагт өгөгдөх “илчлэлтүүдээр титэм өмсгөгдөх болно.

5 Иймийн тул, бибээр тэдэнд зарлиг болгон ийн хэлэв: Чи Их Эзэн Бурханаа бүх “зүрх сэтгэлээрээ, өөрийн бүх хүчин чадал, оюун хийгээд чадлаараа ^бхайрлах

59 1a Мат. 6:22-24;
С ба Г 88:67.
2a Мат. 5:5;
С ба Г 63:20, 48-49.
б Илч. 14:13.
су Биеийн үхэл;
Диваажин.
в Иохан 14:2;
С ба Г 72:4; 76:111;

81:6; 98:18.
г су Титэм;
Өргөмжлөл.
3a Эхл. 4:12; Мосе 5:37.
4a су Зөв зохистой,
Зөв зохистой
байдал.
б су Хичээл зүтгэл.
в С ба Г 42:61; 76:7;

98:12; 121:26-29.
су Илчлэлт.
5a су Зүрх сэтгэл.
б Дэд хууль 11:1;
Мат. 22:37;
Моро. 10:32;
С ба Г 20:19.
су Хайр.

ёстой; мөн Есүс Христийн нэрээр чи түүнд “үйлчлэх ёстой.

6 Чи “хөршөө өөр шигээ хайрлах ёстой. Чи ^бхулгайлах ёсгүй; тэрчлэн ^всадар самууныг үйлдэх буюу “хүн алах ёсгүй, тэрчлэн энэ мэт ямар ч зүйлийг үйлдэх ёсгүй.

7 Чи Их Эзэн Бурхандаа бүх зүйлд “талархах ёстой.

8 Чи Их Эзэн Бурхандаа “зөв шударга байдалд, бүр харууссан зүрх мөн ^бгэмшсэн сэтгэлтэйгээр ^взолиослол өргөх ёстой.

9 Мөн чи өөрийгөө дэлхийгээс илүү бүрэн дүүрэн “толбогүй байлгаж болгохын тулд, чи залбирлын өргөөнд очиж мөн миний ^бариун өдөрт ариун ёслолуудаа өргөх ёстой;

10 Учир нь үнэнээр энэ бол хөдөлмөрүүдээсээ амрахаар, мөн Бүхний Дээдэд чи бүхнээ “зориулахаар чамд өгөгдсөн өдөр юм;

11 Гэсэн хэдий ч, чиний амлалтууд бүхий л өдрүүдэд мөн бүхий л цагт зөв шударга байдалд өргөгдөх ёстой;

12 Гэхдээ энэхүү, Их Эзэний өдөр, чи нүглүүдээ ахан дүүстээ, мөн Их Эзэний өмнө

“хүлээж, өөрийнхөө ^бөргөлүүд хийгээд өөрийнхөө ариун ёслолуудыг Бүхний Дээдэд өргөх ёстой гэдгийг санагтун.

13 Мөн чиний “мацаг барилт төгс байж болохын тулд, эсвээс, өөр үгээр, ^ббаяр хөөр чинь дүүрэн байж болохын тулд энэ өдөр чи хоол хүнсээ гагцхүү чин сэтгэлээсээ бэлтгэхээс өөр юу ч хийх ёсгүй.

14 Үнэнээр, энэ бол мацаг ба залбирал юм, эсвээс өөрөөр хэлбэл, баяр баясгалан хийгээд залбирал юм.

15 Мөн эдгээр зүйлүүдийг та нар “талархалтайгаар, ^ббаяр хөөртэй “зүрх сэтгэл хийгээд, дүр төрхтэйгөөр, их “инээдтэйгээр бус, учир нь энэ нь нүгэл бөлгөө, харин баяртай зүрх сэтгэл хийгээд хөгжил хөөртэй дүр төрхтэйгөөр хийхийн хэрээр болой—

16 Үнэнээр би хэлдэг, та нар үүнийг хийхийн хэрээр, дэлхийн бүрэн байдал та нарынх бөлгөө, хээрийн амьтад хийгээд агаарын жигүүртнүүд, мөн модонд авирагч хийгээд газар дээгүүр явагч тэдгээр нь буюу;

17 Тийм ээ, хоол хүнс эсвээс хувцас хунарын тулд, эсвээс

5в су Үйлчлэл.

6а су Нөхөрлөл.

б су Хулгай хийх,
Хулгай.

в су Завхайрал.

г су Аллага.

7а Дуул. 92:1;

Алма 37:37;

С ба Г 46:32.

су Талархалтай,
Талархах, Талархал
өргөх.

8а су Зөв шударга,

Зөв шударга ёс.

б су Харууссан зүрх.

в су Золиослол.

9а Иаков 1:27.

б су Хүндэтгэлийн
өдөр.

10а су Шүтэн бишрэх.

12а су Хүлээн
зөвшөөрөх, Хүлээн
зөвшөөрөлт.

б ө.х. Бурхан болон
бусад хүний
төлөөх үйлчлэлд

цаг зав, авьяасаа

мөн, туламж өгөх.
су Золиослол.

13а су Мацаг барих,
Мацаг барилт.

б су Баяр баясгалан.

15а су Талархалтай,
Талархах, Талархал
өргөх.

б Ег. 25:2; С ба Г 64:34.

в Сур. үгс 17:22.

г С ба Г 88:69.

орон гэр буюу оромжийн тулд, эсвээс жимсний цэцэрлэг буюу цэцэрлэгүүдийн тулд, эсвээс усан үзмийн талбайн тулд дэлхийгээс ирдэг сайн зүйлүүд түүнчлэн өвс ургамал буюу;

18 Тийм ээ, “дэлхийгээс, өөр өөрсдийн цагт ирдэг бүх зүйл, хүмүүний тусын тулд мөн ашиглалтын тулд, нүд баясгах хийгээд сэтгэл баярлуулах аль алиных нь тулд хийгдсэн болой;

19 Тийм ээ, хоол хүнс хийгээд хувцас хунарын тулд, амт хийгээд үнэрийн тулд, бие махбодийг хүчирхэгжүүлэх хийгээд сүнсэнд эрч хүч өгөхийн тулд болой.

20 Мөн эдгээр бүх зүйлийг хүмүүнд өгсөн нь Бурханыг баярлуулдаг; энэхүү зорилгын учир эдгээр нь ухаалгаар, хэт илүү бишээр, хүч түрэмгийллээр бус ашиг-

лагддаг байхаар хийгдсэн бөлгөө.

21 Мөн бүх зүйл дээр түүний гарыг “хүлээн зөвшөөрдөггүй, мөн түүний зарлигуудыг дуулгавартайгаар үл дагадаг тэднээс бусад хүмүүн ямар ч зүйлээр Бурханд ^бгэм бурууг үйлддэггүй, эсвээс хэний ч эсрэг түүний уур хилэн дүрэлздэггүй.

22 Болгоогтун, энэ нь хууль хийгээд бошиглогчдын дагуу юм; иймийн тул, энэ асуудлын талаар дахиад надад бүү төвөг удагтун.

23 Гэвч “зөв шударгын үйлсүүдийг хийх тэрээр ^бшагналаа, бүр энэ дэлхийд ^аамар амгаланг хийгээд ирэх дэлхийд ^вмөнх амьдралыг хүлээн авах болно гэдгийг мэдэж авагтун.

24 Их Эзэн, бибээр үүнийг ярилаа, мөн Сүнс гэрчилдэг бөлгөө. Амен.

ХЭСЭГ 60

1831 оны Наймдугаар сарын 8-нд Миссурийн Жаксон гүнлэгт Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:201–202). Энэ үйл явдлаар дорнод уруу эргэж явахаар томилогдсон ахлагчид хэрхэн явах хийгээд ямар чиглэлээр мөн ямар байдлаар тэд аялбал зохихыг мэдэхийг хүсчээ.

1–9, Ахлагчид ёс бусчуудын цугларалтууд дээр сайн мэдээг номлох ёстой; 10–14, Тэд цагаа дэмий үрэх, тэрчлэн авьяас чадваруудаа бууллах ёсгүй; 15–17, Тэд Сайн мэдээг эсэргүүцэгч

тэдний эсрэг гэрчлэл болгон хөлөө угааж болно.

БОЛГООГТУН, хүрч ирсэн тэр нутаг уруугаа үтэр түргэн эргэн явах ёстой

18a су Газар дэлхий.
21a Иов 1:21.
б су Гомдоох.
23a су Зөв шударга,

Зөв шударга байдал.
б су Адислах,
Адислагдах,

Адислал.
в Мат. 11:28–30.
су Амар амгалан.
г С ба Г 14:7.

өөрийн сүмийн ахлагчдад Их Эзэн ийн хэлж байна: Болгоогтун, та нар ийшээ хүрч ирсэн нь миний таалалд нийцнэ;

2 Гэвч зарим нь миний таалалд үл нийцнэ, учир нь тэд “амаа нээх нь үгүй, харин тэд хүнээс ^бэмээхийн улмаас тэдэнд миний өгсөн авьяас билгийг тэд “нуух ажээ; Иймүүдэд нь халаг, учир нь тэдний эсрэг миний уур дүрэлзэнэ.

3 Мөнхүү улиран тохиох дор, хэрэв тэд надад илүү итгэлтэй байхгүй аваас, энэ нь, бүр тэдэнд байгаа нь хүртэл “авагдах болно.

4 Учир нь Их Эзэн, бибээр дээр тэнгэрт, мөн дэлхийн “их цэргийн дунд захирдаг билээ; мөн бибээр өөрийн ^бэрдэнэсийг сонгож авах тэр өдөр, Бурханы сүр хүчийг нотлогч тэр зүйл юу болохыг бүх хүмүүн мэдэх болно.

5 Гэвч, ирсэн тэрхүү нутаг уруугаа та нарын хийх аяны талаар би та нарт үнэнээр хэлье. Та нарт сайн санагдсанаар хөлөг онгоц хийгдэг, эсвээс худалдаж авагдах, энэ нь надад хамаагүй билээ, мөн та нар Сейнт Люис хэмээн нэрлэгдэх газрыг зорин аян замдаа үтэр түргэн гарцгаагтун.

6 Мөн тэндээс миний үйлчлэгчид Сидней Ригдон, Бага

Иосеф Смит, мөн Оливер Каудери нар Цинцинатыг зорин аян замдаа гараг;

7 Мөн энэ нутагт тэд дуу хоолойгоо өргөж мөн миний үгийг чанга дуу хоолойгоор, хилэгнэл буюу эргэлзээгүйгээр, тэдэн дээр ариун гараа өргөн тунхаглаг. Учир нь бибээр та нарыг “ариун болгох чадвартай бөлгөө, мөн нүглүүд чинь та нарт ^бөршөөгдсөн болой.

8 Мөн үлдэгсэд нь Сейнт Люисээс, хоёр хоёроороо аян замдаа гарч мөн, өөрсдийнхөө ирсэн тэрхүү сүмүүддээ эргэж очих хүртлээ ёс бусчуудын цугларалтуудад яаралгүйгээр үгийг номлог.

9 Мөн энэ бүхэн сүмүүдийн сайн сайхны төлөө бөлгөө; учир нь энэхүү зорилгын улмаас би тэднийг илгээсэн билээ.

10 Мөн миний үйлчлэгч “Эдвард Партриж өөрт нь миний өгсөн мөнгөнөөс нэг хэсгийг нь эргэж явахаар зарлигдуулсан миний ахлагчдад өгөг;

11 Мөн чадах тэр нь үүнийг төлөөний хүнээр дамжуулан эргүүлж өгөг; мөн эс чадах түүнээс энэ нь шаардагдах нь үгүй.

12 Мөн эдүгээ бибээр энэ нутагт ирэх ёстой үлдэгсдийн талаар ярья.

13 Болгоогтун, ёс бусчуудын

60 2a Ефес 6:19–20.

б Мат. 25:14–30.

сү Айх—Хүнээс айх.

в Лук 8:16, 18.

3a Марк 4:25;

С ба Г 1:33.

4a Алма 43:50.

б Иса. 62:3; Зех. 9:16;

Малах. 3:17;

С ба Г 101:3.

7a сү Ариун байдал.

б сү Уучлах.

10a сү Эдвард

Партриж.

цугларалтуудад миний сайн мэдээг номлохоор тэд илгээгдсэн билээ; иймийн тул, бибээр тэдэнд ийн зарлиглаж байна: Авьяас билиг чинь мэдэгдэхгүй байхын улмаас чи цагаа “дэмий үрэх ёсгүй, тэрчлэн чи авьяас билгээ булшлах ёсгүй.

14 Мөн чи Сионы нутагт ирснийхээ мөн миний үгийг тунхагласныхаа дараа, чи ёс бусчуудын цугларалтуудад миний үгийг яаралгүйгээр бас “хилэгнэл хийгээд тэмцэл зөрчилд биш номлон, үтэр түргэн буцах ёстой.

15 Мөн чи тэднийг өдөөн

хатгахгүйн тулд тэдний дэргэд биш, харин далдуур, та нарыг үл хүлээн авах тэдний эсрэг хөлийнхөө “тоосыг гүвэгтүн; мөн шүүлтгийн өдөр тэдний эсрэг гэрчлэл болгон хөлөө угаагтун.

16 Болгоогтун, энэ нь та нарын хувьд хангалттай болой мөн чамайг илгээсэн түүний таалал болой.

17 Мөн Сидней Ригдон болон Оливер Каудерийн талаарх заавар нь миний үйлчлэгч Бага Иосеф Смитийн амаар мэдүүлэгдэх болно. Үлдсэн нь үүнээс хойш буюу. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 61

1831 оны наймдугаар сарын 12-нд Миссури мөрний эрэг, Макилвейны тохойд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:202–205). Көртланд уруу буцах замдаа, Бошиглогч болон арван ахлагч Миссури Мөрнийг уруудан завиар аялжээ. Аяллын гурав дахь өдөр олон аюул тулгарав. Ахлагч Виллям В.Фелпс, өдрийн цагаарх нэгэн үзэгдэлд, их усны гадаргуу дээр сүр хүчинд давхигч устгагчийг харжээ.

1–12, Их Эзэн их усан дээр олон устгалыг бий болгожээ; 13–22, Их ус нь Иоханаар зүхэгдэж, мөн түүний гадаргуу дээр устгагч аялдаг; 23–29, Их усанд зарлиглах хүч заримд нь буй; 30–35, Ахлагчид хоёр хоёроороо аялж мөн сайн мэдээг номлох ёстой; 36–39, Тэд Хүний Хүүгийн ирэлтэд бэлтгэх ёстой.

БОЛГООГТУН, мөн бүх Б^асүр хүч түүнд буй, үүрд мөнхөөс үүрд мөнхөд байдаг, бүр ^бАльфа ба Омега, эхлэл ба төгсгөл болох түүний дуу хоолойг анхаарагтун.

2 Болгоогтун, Ай энэ газарт цугларсан миний сүмийн ахлагчид та нар, нүглүүд тань эдүгээ та нарт “өршөөгдсөн

13а С ба Г 42:42.
су Залхуурах,
Залхуу байдал.
б Мат. 25:24–30;
С ба Г 82:18.

14а Сур. үгс 14:29.
15а Мат. 10:14; Лук 9:5;
Үйлс 13:51;
С ба Г 24:15;
75:20; 84:92.

61 1а су Хүч.
б су Альфа ба Омега.
2а Мозая 4:10–11.
су Уучлах.

болой, учир нь Их Эзэн, бибээр нүглүүдийг өршөөдөг, мөн даруухан зүрхээр нүглүүдээ ⁶гэмшдэг тэдэнд “нигүүлсэнгүй байдаг хэмээн үнэнээр ийн Их Эзэн та нарт хэлнэм;

3 Гэвч хоёр талд оршин суугчид итгэлгүйд мөхөж буй үед миний ахлагчдын энэхүү нийт хамтлагийн хувьд их усан дээгүүр шаламгайлан урагш ахих нь шаардлагагүй бусыг үнэнээр би та нарт хэлж байна.

4 Гэсэн хэдий ч, та нар гэрчилж болохын тулд би үүнийг зөвшөөрсөн болой; болгоогтун, их усан дээр олон аюул буй, мөн нэн ялангуяа үүнээс хойш бүр ч илүү буй;

5 Учир нь, Их Эзэн бибээр уурандаа их усан дээр; тийм ээ, мөн ялангуяа эдгээр их усан дээр олон устгалыг бий болгосон бөлгөө;

6 Гэсэн хэдий ч, бүх махбодь миний гарт буй, мөн та нарын дундах итгэлтэй тэр нь их усанд мөхөх нь үгүй бөлгөө.

7 Иймийн тул, миний үйлчлэгч Сидней Гилберт мөн миний үйлчлэгч “Виллям В.Фелпс нар өөрсдийнхөө даалгавар хийгээд ажил үүрэгт шуурхай байх нь зүйтэй бөлгөө.

8 Гэсэн хэдий ч, та нар нэг байж болохын тулд, та нар “ёс

буст мөхөхгүй байж болохын тулд, та нар бүх нүглүүддээ ⁶гэсгээн цээрлүүлэгдэх хүртлээ, та нар салж явахыг чинь би үл зөвшөөрнө;

9 Гэвч эдүгээ, та нар салж явах ёстой нь надад шаардлагатай байна, иймийн тул, миний үйлчлэгчид Сидней Гилберт, мөн Виллям В.Фелпс нар урьдах байдлаараа хос болж, мөн тэд ажил үүргээ биелүүлж болохын тулд аян замдаа яаруу гараг, мөн итгэлээр дамжуулан тэд даван туулах болно хэмээн үнэнээр би хэлж байна;

10 Мөн итгэлтэй байхын хэрээр тэд хамгаалагдах болно, мөн Их Эзэн бибээр тэдэнтэй хамт байх болно.

11 Мөн үлдэгсэд нь хувцаслахад шаардлагатай зүйлийг авагтун.

12 Миний үйлчлэгч Сидней Гилберт шаардлагатай бус зүйлийг, та нарын зөвшөөрснөөр авч яваг.

13 Мөн эдүгээ, болгоогтун, та нарын “сайн сайхны тул эдгээр зүйлүүдийн талаар би та нарт нэг ⁶зарлиг өглөө; мөн Их Эзэн бибээр эрт дээр үеийн хүмүүсийн адилаар та нартай хэлэлцэх болно.

14 Болгоогтун, Их Эзэн бибээр, эхлэлд их “усыг адисалсан билээ; харин эцсийн өдрүүдэд, өөрийн үйлчлэгч

2б су Хүлээн зөвшөөрөх, Хүлээн зөвшөөрөлт.
в су Нигүүлсэнгүй, Нигүүлсэл.

7а су Виллям В.Фелпс.
8а су Ёс бус, Ёс бус байдал.
б су Зэмлэх, Зэмлэл.
13а С ба Г 21:6.

б су Бурханы зарлигууд.
14а Эхл. 1:20.

Иоханы амаар би их усыг
 6 зүхсэн юм.

15 Иймийн тул, аливаа мах-
 бодь их усан дээр аюулгүй
 байх тэрхүү өдрүүд ирэх
 болно.

16 Мөн зүрх сэтгэлдээ цэх
 шулуун түүнээс өөр хэн ч
 Сионы нутаг уруу их усан
 дээгүүр өгсөн явж чадахгүй
 болой, ирэх өдрүүдэд энэ нь
 хэлэгдэх болно.

17 Мөн Их Эзэн, бибээр эх-
 лэлд уг нутгийг “зүхсэнчлэн,
 мөн бүр эцсийн өдрүүдэд
 үүнийг, өөрийнх нь цаг үед,
 тэд дэлхийн сайн зүйлүү-
 дийг хүртэж болохын тулд
 миний гэгээнтнүүд ашигла-
 хын тулд адисалсан болой.

18 Мөн эдүгээ би та нарт
 нэг зарлиг өгье, мөн би нэгд
 хэлснийгээ бүгдэд хэлдэг,
 тэд тэдгээрийн дээр аялалд
 ирэхгүйн тулд, тэдний ит-
 гэл мөхөж мөн тэд урхинд
 баригдахгүйн тулд эдүгээ
 их усны тухай та нар ахан
 дүүстээ урьдчилан сануулах
 болно;

19 Их Эзэн, бибээр тунхаг-
 ласан, мөн тэдгээрийн га-
 даргуу дээр устгагч аялдаг,
 мөн бибээр уг тогтоолыг
 цуцлах нь үгүй бөлгөө.

20 Их Эзэн, бибээр очигдөр
 та нарт ууртай байлаа, гэвч
 өнөөдөр миний уур гарлаа.

21 Иймийн тул, өөрсдийнх
 нь талаар миний ярьсан тэд
 аян замдаа яаруу гараг — да-
 хин би та нарт хэлнэ, тэд аян
 замдаа яаруу гараг.

22 Мөн хэрэв тэд зорилгоо
 биелүүлэх аваас тэд арай
 хо жуухан усаар буюу
 эсвээс газраар явна уу гэдэг
 нь надад хамаагүй хэрэг;
 үүнээс хойш тэдний шийд-
 сэний дагуу энэ нь тэдэнд
 мэдүүлэгдэг.

23 Мөн эдүгээ миний үйлч-
 лэгчид Сидней Ригдон, Бага
 Иосеф Смит мөн Оливер
 Каудери нарын тухайд, энэ
 нь суваг дээгүүр гэртээ харих
 аялал биш байх аваас тэд их
 усан дээгүүр дахин бүү яваг;
 эсвээс өөр үгээр, хэрэв суваг
 дээр биш аваас, тэд аялахаар
 их усан дээр гарах ёсгүй.

24 Болгоогтун, Их Эзэн,
 бибээр өөрийн гэгээнтнүү-
 дийн аялалд зориулсан замыг
 өгсөн бөлгөө; мөн болгоог-
 тун, энэ бол—тэд сувгийг
 орхисны дараа Сионы нутаг
 өөд аялж мөн өгсөн ява-
 хаар тэд зарлиг болгогдох
 үед газраар аялах тэрхүү зам
 болой;

25 Мөн тэд замдаа майх-
 нуудаа “босгон, Израилын
 хүүхдүүдийн адилаар үйлдэх
 ёстой.

26 Мөн, болгоогтун, энэхүү
 зарлигийг та нар бүх ах дүүс-
 тээ өгөх ёстой.

27 Гэсэн хэдий ч, их усанд
 зарлиглах “хүч өгөгдсөн
 түүнд, түүний бүх замуудыг
 мэдэх нь Сүнсээр түүнд
 өгөгдсөн ажгуу;

28 Иймийн тул, газар дээр ч
 байна уу эсвээс их усан дээр
 ч байна уу, үүнээс хойш

үйлдэх нь надад үлдэхийн адилаар амьд Бурханы Сүнс түүнд зарлигласны дагуу тэрбээр үйлдэг.

29 Мөн гэгээнтнүүдэд зориулсан чиглэл буюу гэгээнтнүүд аялахад Их Эзэний зам буудал байх арга зам та нарт өгөгдсөн буй.

30 Мөн дахин, миний үйлчлэгчид Сидней Ригдон, Бага Иосеф Смит, мөн Оливер Каудери нар Цинцинатид очих хүртлээ ёс бусчуудын цугларалтууд дээр амаа нээх ёсгүй бөлгөө;

31 Мөн тэрхүү газарт тэд тэр хүмүүсийн эсрэг, Бурханд, тийм ээ, устгалд яггүй сайн “боловсорсон хүмүүс, тэдний ёс бусын эсрэг уур нь дүрэлзсэн түүнд дуу хоолойгоо өргөх ёстой.

32 Мөн тэндээс ах дүүсийнхээ цугларалтуудын тулд тэд аялаг, учир нь тэдний хөдөлмөрүүд ёс бусчуудын цугларалтуудын дундахаас тэдний дунд эдүгээ бүр илүү хүсэгдэж буй ажгуу.

33 Мөн эдүгээ, үлдэгсдийн тухайд, тэд ёс бусчуудын цугларалтуудын дунд аялж мөн энэ нь өгөгдөхийн хэрээр үгийг “тунхаглаг;

34 Мөн тэд үүнийг үйлдэхийн хэрээр тэд өмсгөлүүдээ “ангижруулах болно, мөн тэд

миний өмнө толбогүй байх болно.

35 Мөн тэд хамтаараа эсвээс тэдэнд сайн санагдсанаар “хоёр хоёроороо аялаг, гагцхүү миний үйлчлэгч Рейнолдс Кахун, миний таалалд нийцдэг, миний үйлчлэгч Самуел Х.Смит нар гэр рүүгээ эргэж явах хүртлээ бүү салаг, мөн энэ нь надад орших мэргэн зорилгын учир бөлгөө.

36 Мөн эдүгээ, би нэгд хэлснээ бүгдэд хэлдэг гэдгийг үнэнээр би та нарт хэлдэг, зоригтой байгтун, “бяцхан хүүхдүүд минь; учир нь бибээр та нарын ^бдунд байна, мөн бибээр та нарыг ^аорших нь үгүй;

37 Мөн та нар өөрсдийгөө миний өмнө даруусгахын хэрээр, “хаант улсын адислалууд та нарынх бөлгөө.

38 Хормойгоо шууж мөн Хүний Хүүгийн ирэлтийг хүлээн ^асонор сэргэг мөн хэрсүү байгтун, учир нь тэрбээр та нарын санаагүй цагт ирэх буюу.

39 Та нар “уруу таталтанд орохгүйн тулд, амьд буюу нас барсан алин ч болов та нар түүний ирэлтийн өдрийг тэсэн гарч болохын тулд, ямагт ^бзалбирагтун. Бүр тийм буюу. Амен.

31а Алма 37:31;
Хил. 13:14;
С ба Г 101:11.

33а су Номлох;
Гэрчлэх.

34а 2 Ниф. 9:44;
Иаков 2:2;

Мозая 2:28.
35а су Номлолын
ажил.

36а Иохан 13:33.
б Мат. 18:20.

в Иса. 41:15–17;
1 Ниф. 21:14–15.

37а С ба Г 50:35.

38а су Харах, Харуул.
39а су Уруу татах, Уруу

таталт.
б су Залбирал.

ХЭСЭГ 62

1831 оны наймдугаар сарын 13-нд Миссури мөрний эрэг дээрх Чаритонд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:205-206). Энэ өдөр Бошиглогч болон түүний бүлэг Индепенденсээс Көртланд уруу явах замдаа Сионы нутаг уруу явж байсан хэсэг ахлагчидтай уулзаж, мөн баяр хөөртэйгөөр мэндлэлцсэний дараа энэхүү илчлэлтийг хүлээн авчээ.

1-3, Гэрчлэлүүд тэнгэрт цэдэглэгддэг болой; 4-9, Ахлагчид өөрсдийнхөө шийдвэрийн дагуу хийгээд Сүнсээр чиглүүлэгдсэнээр аялж мөн номлох ёстой.

БОЛГООГТУН, мөн анхаарагтун, Ай миний сүмийн ахлагчид та нар хэмээн, та нарын Бурхан Их Эзэн, бүр Есүс Христ, хүмүүний сул талыг хийгээд “уруу татагдсан тэдэнд хэрхэн” туслахыг мэддэг, та нарын “өмгөөлөгч тэрээр хэлж байна.

2 Мөн үнэнээр миний мэлмий Сионы нутаг өөд хараахан өгсөн яваагүй байгаа тэдэн дээр байна; иймийн тул, та нарын ажил үүрэг хараахан дуусаагүй байна.

3 Гэсэн хэдий ч, адислагдсан болой та нар, учир нь та нарын гэрчилсэн “гэрчлэл тэнгэр элчүүд харж байхын тулд тэнгэрт” цэдэглэгддэг болой; мөн тэд та нарт баясдаг бөлгөө, мөн “нүглүүд тань өршөөгдсөн болой та нарт.

4 Мөн эдүгээ аяллаа үргэлжлүүлэгтүн. “Сионы ну-

таг дээр өөрсдийгөө цуглуулагтун; мөн цуглаан явуулж мөн хамтдаа баясацгаа, Бүхний Дээдэд ариун ёслолыг өргөгтүн.

5 Мөн тэгээд та нар гэрчлэхийн тулд эргэж очиж болох бөлгөө, тийм ээ, бүр та нарт сайн санагдсанаар бүгд хамтдаа, эсвээс хоёр хоёроороо буюу, энэ нь надад хамаагүй бөлгөө; гагцхүү итгэлтэй байж мөн баярт мэдээнүүдийг дэлхийн оршин суугчдад, эсвээс ёс бусчуудын цугларалтуудын дунд “тунхаглагтун.

6 Болгоогтун, амлалт биелэгдэж болохын тулд, та нарын дундах итгэлтнүүд хамгаалагдаж мөн Миссурийн нутагт хамтдаа баясахын тулд Их Эзэн бибээр та нарыг хамтад нь авчирлаа. Их Эзэн бибээр итгэлтнүүдэд амладаг мөн “худал хэлэх нь үгүй.

7 Хэрэв та нарын дотроос хэн нэгэн чинь мориор, луусаар, эсвээс сүйх тэргээр явахыг хүсэх аваас Их Эзэн бибээр зөвшөөрч бэлэн бай-

62 1a су Уруу татах, Уруу таталт.
б Евр. 2:18; Алма 7:12.
в С ба Г 45:3-4.
су Өмгөөлөгч.

3a Лук 12:8-9.
су Гэрчлэл.
б су Амьдралын ном.
в С ба Г 84:61.

4a С ба Г 57:1-2.
5a су Номлолын ажил.
6a Ифер 3:12.

на, хэрэв тэрээр үүнийг Их Эзэний гараас, бүх зүйлд “талархах сэтгэлээр хүлээн авбал, тэрээр энэхүү адислалыг хүлээн авах болно.

8 Шийдвэр хийгээд Сүсний чиглүүлүүдийн дагуу

эдгээр зүйлүүдийг хийх нь та нарт үлдэх авай.

9 Болгоогтун, “хаант улс та нарынх бөлгөө. Мөн болгоогтун, мөн харагтун, бибээр итгэлтнүүдтэй ямагт “хамт байна. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 63

1831 оны наймдугаар сарын сүүлчээр Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:206–211). Бошиглогч, Сидней Ригдон мөн Оливер Каудери нар Миссури уруу хийсэн айлчлалаасаа Көртландад наймдугаар сарын 27-нд буцаж иржээ. Энэхүү илчлэлтийн цэдгийн оршилд Бошиглогч бичихдээ, “Сүмийн энэхүү нялх балчир үед, бидний авралд хамаарах аливаа арга замын сэдэв болгоноор Их Эзэний үгийг олж авах нь агуу их хүсэл эрмэлзэл байлаа; мөн Сионы нутаг эдүгээ нэн их ач холбогдол бүхий материаллаг зүйл болсныг харгалзан, Гэгээнтнүүдийн цугларалт, мөн газар худалдаж авах хийгээд бусад асуудлын талаар нэмэлт мэдээллийг Их Эзэнээс би хүссэн билээ” гэжээ (History of the Church, 1:207).

1–6, Хилэгнэлийн өдөр ёс бусчууд дээр тохиох болно; 7–12, Тэмдгүүд итгэлээр ирдэг болой; 13–19, Зүрх сэтгэлдээ садарлагчид итгэлийг үгүйсгэх бөгөөд галт нууранд хаягдах болно; 20, Итгэлтнүүд өөрчлөгдсөн дэлхий дээр өв хүлээн авах болно; 21, Өөрчлөлтийн Уулан дээрх үйл явдлуудын бүрэн шастир хараахан илчлэгдээгүй бөлгөө; 22–23, Дуулгавартнууд хаант улсын нууцуудыг хүлээн авдаг ажгуу; 24–31, Сионд өмч хөрөнгө худалдан авагдах ёстой; 32–35, Их Эзэн дайнуудыг тогтоодог мөн ёс бусчууд ёс бусчуудыгаа хөнөөдөг 36–48, Гэгээнтнүүд Сионд цугларч мөн үүнийг барих мөнгөөр хангах ёстой; 49–54, Хоёр-

дахь Ирэлтэд, Амилуулалтад, мөн Мянганы туршид адислалууд итгэлтнүүдэд амлагдсан билээ; 55–58, Энэ бол сэрэмжлүүлгийн өдөр болой; 59–66, Үүнийг эрх мэдэлгүйгээр хэрэглэдэг тэднээр Их Эзэний нэр хоосонд аваачигддаг бөлгөө.

АНХААРАГТУН, Ай хүмүүс
Та нар, мөн зүрх сэтгэлээ нээж мөн холоос чих тавигтун; мөн дуулагтун; өөрсдийгөө Их Эзэний хүмүүс хэмээн дууддаг та нар, мөн Их Эзэний үг хийгээд өөрсдийнхөө талаарх түүний тааллыг сонсогтун;

2 Тийм ээ, үнэнээр би хэлнэ, ёс бусчууд хийгээд

“эсэргүүцэгчдийн эсрэг уур нь дүрэлзэж буй түүний үгийг сонсогтун.

3 Бүр тэднийг “авахыг хүсдэг тэрээр тэднийг авах түүнийг, мөн амьдралд хамгаалах тэднийг, амьдралд хамгаалах түүнийг буюу.

4 Өөрийн таалал хийгээд таашаалаар байгуулдаг түүнийг; мөн хүссэн үедээ устгадаг, мөн бодгалийг доош нь тамд хаяж чадах түүнийг буюу.

5 Болгоогтун, Их Эзэн бибээр дуу хоолойгоо илэрхийллээ, мөн энэ нь дуулгавартай дагагдах болно.

6 Иймийн тул, үнэнээр би хэлнэ, ёс бусчууд анхаараг, мөн эсэргүүцэгчид эмээж мөн дагжин чичрэг; мөн үл итгэгчид уруулаа хамхиг, учир нь хилэгнэлийн “өдөр тэдэн дээр ⁶хуй салхи мэт ирэх болно, мөн намайг Бурхан гэдгийг бүх махан бодь ⁶мэдэх болно.

7 Мөн тэмдгүүдийг эрэлхийлдэг тэрээр “тэмдгүүдийг харах болно, гэвч авралд биш бөлгөө.

8 Үнэнээр, би та нарт хэлнэ, тэмдгүүдийг эрэлхийлдэг тэд та нарын дунд буй, мөн иймүүд нь бүр эхлэлээс байгаа бөлгөө;

9 Гэвч, болгоогтун, итгэл тэмдгүүдээр ирдэггүй, харин

итгэдэг тэднийг тэмдгүүд дагалддаг буюу.

10 Тийм ээ, тэмдэг нь хүмүүний хүсэл зоригоор ч бус, бас тэдний хүсэл эрмэлзлэлээр ч бус, харин Бурханы тааллаар, “итгэлээр ирдэг авай.

11 Тийм ээ, тэмдгүүд итгэлээр хүчирхэг ажлуудад ирдэг бөлгөө, учир нь “итгэлгүйгээр хүмүүн Бурханд таалагдах нь үгүй; мөн Бурхан түүнд уурласан тэрээр таалагдах нь үгүй; иймийн тул, тэрээр тэмдгүүдийг иймүүдэд үзүүлэх нь үгүй, гагцхүү ⁶хилэгнэлд тэдний “зэмлэлийг буюу.

12 Иймийн тул, миний алдар суугийн төлөө хүмүүний сайн сайхны төлөө бус, итгэлийн төлөө тэмдгүүд хийгээд гайхалтай зүйлүүдийг эрэлхийлдэг байсан та нарын дундах тэднийг Их Эзэн бибээр үл таалдаг бөлгөө.

13 Гэсэн хэдий ч, би зарлигуудыг өгдөг, мөн олон нь миний зарлигуудаас нүүр буруулж мөн тэдгээрийг сахьдаггүй байв.

14 Та нарын дунд “садарлагч эрчүүд мөн садарлагч эмс байлаа; тэдний зарим нь та нараас нүүр буруулсан билээ, мөн бусад нь та нартай хамт үлдсэн, тэд үүнээс хойш илчлэгдэх болно.

15 Шүүлт тэдэн дээр занга

63 2a су Эсэргүүцэл.
3a су Биенийн үхэл.
6a су Шударга ёс;
Есүс Христийн
Хоёр дахь Ирэлт.

6 Иер. 30:23.
в Иса. 49:26.
7a С ба Г 46:9.
су Тэмдэг.
10a Моро. 7:37.

су Итгэл.
11a Евр. 11:6.
б С ба Г 35:11.
в С ба Г 88:65.
14a С ба Г 42:24–25.

лугаа адил ирэхийн учир иймүүд нь болгоомжилж мөн үтэр түргэн наманчлаг, мөн тэдний тэнэглэл илэрхийлэгдэх болно, мөн хүмүүсийн нүдэнд тэдний ажлууд тэднийг дагалдах болно.

16 Мөн би өмнө нь хэлсэнчлэн, үнэнээр би та нарт хэлнэ, эмэгтэй хүнийг “тачаангуйгаар ^бхарах тэрээр, эсвээс хэрэв хэн нэг нь зүрх сэтгэлдээ ^всадар самууныг үйлдэх аваас, тэдэнд Сүнс байх нь үгүй, харин тэд итгэлийг үгүйсгэж мөн эмээх болно.

17 Иймийн тул, “эмээгчид мөн үл итгэгчид мөн бүх ^бхудал хэлэгчид мөн худал ^вхэлэхэд дуртай хийгээд худал хэлдэг хэн ч гэсэн, мөн завхай хүмүүс, мөн мэрэг төлөгчид, ^гхоёр дахь үхэл болох гал болон хүхрээр авалцан шатагч тэрхүү ^днууранд өөрсдийн хувьтай байх болно гэдгийг Их Эзэн бибээр хэлсэн билээ.

18 “Анхны амилуулалтад тэд хувьгүй байх болно гэдгийг үнэнээр би хэлдэг.

19 Мөн эдүгээ болгоогтун, эдгээр зүйлүүд та нарын дунд байгаа учраас та нар “зөвт-

гөгдөх нь үгүй гэдгийг Их Эзэн бибээр та нарт хэлдэг.

20 Гэсэн хэдий ч, итгэлд “тэсвэрлэж мөн миний тааллыг биелүүлдэг тэрээр, мөнхүү тэрээр дийлэх болно, мөн өөрчлөлтийн өдөр ирэхэд дэлхий дээр ^вөв хүлээн авах болно;

21 Бүр миний төлөөлөгчдөд “уулан дээр үзүүлэгдсэн тэрхүү загварын дагуу ^бдэлхий ^вөөрчлөгдөхөд буюу; үүний шастирын бүрэн байдлыг та нар хараахан хүлээн аваагүй байгаа билээ.

22 Мөн эдүгээ, бибээр өөрийн тааллыг та нарт мэдүүлэх болно хэмээн би та нарт хэлсэн учраас, болгоогтун, би үүнийг та нарт зарлигийн бус замаар мэдүүлэх болно гэдгийг үнэнээр би та нарт хэлж байна, учир нь миний зарлигуудыг анхааралтай дагадаггүй тэд олон буй.

23 Гэвч миний зарлигуудыг сахьдаг түүнд бибээр хаант улсынхаа “нууцуудыг өгнө, мөн мөнхүү эдгээр нь үүрдийн амьдрал уруу ^бурсагч ^вамьд усны худаг түүнд байх болно.

24 Мөн эдүгээ, болгоогтун, өвчин тахал авчрах самуун

16a су Тачаадах.

б Мат. 5:27–28;

С ба Г 42:23–26.

в су Завхайрал.

17a Илч. 21:8.

б су Худал хэлэх.

в Илч. 22:15;

С ба Г 76:103.

г су Сүнсний үхэл.

д Илч. 19:20;

2 Ниф. 9:8–19, 26;

28:23;

Иаков 6:10;

Алма 12:16–18;

С ба Г 76:36.

су Там.

18a Илч. 20:6.

19a су Зөвтгөл,

Зөвтгөх.

20a С ба Г 101:35.

б Мат. 5:5;

С ба Г 59:2; 88:25–26.

21a Мат. 17:1–3.

б су Дэлхий—

Дэлхийн эцсийн байдал.

в су Дэлхий—

Дэлхийн төгсгөл.

23a Алма 12:9–11;

С ба Г 42:61; 84:19;

107:18–19.

б Иохан 4:14.

в су Амьдралын ус.

байхгүйн тулд Сионы нутаг уруу тэд өөрсдийгөө яаралгүйгээр цуглуулах нь та нарын Бурхан Их Эзэний, гэгээнтнүүдийнхээ талаарх таалал юм.

25 Болгоогтун, “Сионы нутгийг — Их Эзэн бибээр үүнийг гартаа барьж байдаг;

26 Гэсэн хэдий ч, Их Эзэн бибээр, Цезарийн зүйлүүдийг “Цезарьт нь өгдөг билээ.

27 Иймийн тул, та нар дэлхийн давуу байдалтай болж болохын тулд, дэлхийд эрхтэй байж болохын тулд, тэд ууранд өдөөн хатгагдахгүй байж болохын тулд та нар газрууд худалдаж авах ёстой хэмээн Их Эзэн бибээр хүснэ.

28 Учир нь “Сатан та нарын эсрэг уурлуулахаар мөн цус урсгахаар тэдний зүрх сэтгэлд үүнийг тавьдаг билээ.

29 Иймийн тул, Сионы нутаг нь худалдан авагдах буюу цусаар бус аваас олдох нь үгүй, эс бөгөөс тэнд та нарын өв гэж байх нь үгүй.

30 Мөн хэрэв худалдан авалтаар бол, болгоогтун адислагдсан болой та нар;

31 Мөн хэрэв цусаар бол, цус урсгах нь та нарт хориглогдсоны учир, харагтун, дайснууд чинь та нарын дээр байна, мөн та нар хотоос хотод, синагогоос синагогт хавчигдан мөрдөгдсөөр байх

болно, мөн харин цөөхөн хэд нь өв хүлээн авахаар үлдэх болно.

32 Их Эзэн бибээр ёс бусчуудад уурлаж байна; бибээр Сүнсээ дэлхийн оршин суугчдаас хол байлгаж байна.

33 Бибээр уур хилэгнэлдээ зэвүүцлээ мөн дэлхийн гадаргуу дээрх “дайнүүдыг тогтоолоо, мөн ёс бусчууд ёс бусчуудыгаа хөнөөх болно, мөн айдас хүн болгон дээр ирэх болно;

34 Мөн “гэгээнтнүүд тэрчлэн арай ядан зугтаах болно; гэсэн хэдий ч, Их Эзэн бибээр тэдэнтэй хамт байна, мөн Эцэгийнхээ дэргэдээс тэнгэрт “бууж ирэх болно мөн унтаршгүй “галаар ‘ёс бусчуудыг залгих болно.

35 Мөн болгоогтун, энэ нь хараахан болоогүй ч, ойрхон мөн ойрхон байна.

36 Иймийн тул, Их Эзэн бибээр, үүнийг хараад дэлхийн гадаргуу дээр эдгээр бүх зүйлийг тогтоолоо, миний гэгээнтнүүд Сионы нутаг дээр цугларахыг би хүснэ;

37 Мөн хүн болгон “зөв шударга ёсыг гартаа мөн итгэл бүхий байдлыг бүсэндээ авч, мөн дэлхийн оршин суугчдад сэрэмжлүүлэх “дуу хоолойгоо өргөхийн тулд буюу; мөн ёс бусчууд дээр “эзгүйрэл тохиох болно гэдгийг үгээр

25а су Сион.

26а Лук 20:25;

С ба Г 58:21–23.

су Засгийн газар.

28а су Чөтгөр.

33а су Дайн.

34а су Гэгээнтэн.

б су Есүс Христийн Хоёр дахь Ирэлт.

в су Гал.

г Мат. 3:12;

2 Ниф. 26:6;

С ба Г 45:57; 64:24;

101:23–25, 66.

су Ёс бус, Ёс бус байдал.

37а су Зөв шударга, Зөв шударга ёс.

б С ба Г 1:4.

в Иса. 47:11.

мөн зугталтаар аль алинаар нь тунхаглагтун.

38 Иймийн тул, Көртландад энэ фермд оршин суух миний шавь нар материаллаг асуудлуудаа зохицуулаг.

39 Тэрээр ирэх хавар Сионы нутаг уруу намайг тэдэнд зарлиглах хүртэл явахгүй байхын тулд, бибээр өөртөө нөөцлөх тэднээс бусад, үүний нүүрэн дээр оршин суух тэдэнтэй хамт хийх аян замдаа бэлтгэгдэж болохын тулд үүний төлөө санаа тавьдаг, миний үйлчлэгч Тит Биллингс уг нутгийг мэдэн зохицуулаг.

40 Мөн өгч чадах бүх мөнгө нь, энэ нь их буюу бага байх нь надад хамаагүй, Сионы нутаг уруу хүлээн авахаар миний томилсон тэдэнд илгээгдэг.

41 Болгоогтун, Их Эзэн бибээр, Сионы нутаг уруу явах тэднийг, мөн миний шавь нараас үлдэх тэднийг тэрээр Сүнсээр “ялган таниж чадах хүчийг өөрийн үйлчлэгч Бага Иосеф Смитэд өгөх болно.

42 Миний үйлчлэгч Ньюел К.Витней дэлгүүрээ, эсвээс өөрөөр хэлбэл, тэрхүү дэлгүүрийг түр хугацаагаар үлдээг.

43 Гэсэн хэдий ч, өөрийн гаргаж чадах бүх мөнгийг, Сионы нутаг уруу илгээгдэхийн тулд тэрээр гаргаг.

44 Болгоогтун, эдгээр зүй-

лүүд түүний өөрийнх нь гарт буй, тэрээр мэргэн ухааны дагуу үйлдэг.

45 Үнэнээр бибээр хэлнэ, үлдэх тэдгээр шавь нарт тэрээр төлөөний хүнээр томилогдог, мөн тэрээр энэ хүчинд томилогдог;

46 Мөн эдүгээ эдгээр зүйлүүдийг тэдэнд тайлбарлан миний үйлчлэгч Оливер Каудерийн хамт сүмүүдээр үтэр түргэн айлчлагтун. Болгоогтун, бүр миний чиглүүлснээр мөнгө олж авах нь, энэ нь миний таалал болой.

47 “Итгэлтэй хийгээд тэсвэрлэдэг тэрээр дэлхийг дийлэх болно.

48 Сионы нутаг уруу сан хөмрөгийг илгээх тэрээр энэ дэлхийд “өв хүлээж авах болно, мөн түүний ажлууд мөн тэрчлэн ирэх дэлхий дэх шагнал түүнийг дагалдах болно.

49 Тийм ээ, Их Эзэнд “талийгаач болсон нас барагсад үүнээс хойш, Их Эзэнийг ирэх хүртэл адислагдсан болой, мөн хуучин зүйлүүд “алга болох болно, мөн бүх зүйл шинэ болно, тэд нас барагсдаас “босч ирэх болно, мөн дараа нь “нас нөгчихгүй байх болно, мөн Их Эзэний өмнө, тэрхүү ариун хотод өв хүлээн авах болно.

50 Мөн Их Эзэнийг ирэхэд амьдарч байх, мөн итгэлээ

41а су Ялган таних бэлэг.

47а Мозая 2:41;
С ба Г 6:13.

48а С ба Г 101:18.

49а Илч. 14:13;
С ба Г 42:44–47.

б 2 Кор. 5:17.
в су Амилуулалт.

г Илч. 21:4;

Алма 11:45;
С ба Г 88:116.
су Мөнх бус, Мөнх бус байдал.

хадгалсаар байх тэр нь, “адислагдсан болой тэрээр; гэсэн хэдий ч, хүмүүний насанд тэрээр ^бнас нөгчих нь түүнд өгөгдсөн бөлгөө.

51 Иймийн тул, хүүхдүүд өтлөх хүртлээ ^аөсөх ^бболно; настай хүмүүс нас нөгчих болно; гэвч тэд тоосонд нойрсох нь үгүй, харин тэд нүд ирмэх зуур ^аөөрчлөгдөх болно.

52 Иймийн тул, энэхүү зорилгын учир нас барагсдын амилуулалтыг төлөөлөгчид дэлхийд номлосон бөлгөө.

53 Эдгээр зүйлүүд бол та нарын эрж хайх ёстой тэрхүү зүйлүүд болой; мөн, Их Эзэний маягаар ярихул, эдүгээ тэдгээр нь “ойрхон байна, мөн ирэх цагт, бүр Хүний Хүүгийн ирэлтийн тэр өдөрт буюу.

54 Мөн тэр цагийг хүртэл мэргэдийн дунд мунхаг “онгон охид байх болно; мөн тэр цагт зөв шударгыг үйлдэгчид хийгээд ёс бусчууд бүрэн салан тусгаарлах нь тохионо; мөн тэрхүү өдөр ёс бусчуудыг ^бсуга татан мөн тэднийг унтаршгүй галд хаяхаар тэнгэр элчүүдээ илгээх болно би.

55 Мөн эдүгээ болгоогтун, үнэнээр би та нарт хэлнэ, Их Эзэн миний таалалд миний

үйлчлэгч “Сидней Ригдон үл нийцэх бөлгөө; тэрээр зүрх сэтгэлдээ өөрийгөө ^бөргөмжлөх болой, мөн зөвлөгөөг хүлээн авсангүй, харин Сүнснийг гомдоосон билээ;

56 Иймийн тул, түүний “бичсэн нь Их Эзэнд хүлээн зөвшөөрөгдөшгүй юм, мөн тэрээр өөр нэгийг хийх болно; мөн хэрэв Их Эзэн үл хүлээн авбаас, болгоогтун, тэрээр миний томилсон тэрхүү албан тушаалд цаашид үүргээ биелүүлэх нь үгүй.

57 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлнэ, нүгэлтнүүдэд наманчлахыг номхон дөлгөөн байдалд “сэрэмжлүүлэхийг зүрх сэтгэлдээ хүсдэг ^бтэд энэхүү хүчинд томилогдог.

58 Учир нь энэ бол сэрэмжлүүлгийн өдөр, мөн олон үгийн өдөр биш бөлгөө. Учир нь Их Эзэн бибээр эцсийн өдрүүдэд доромжлуулахгүй.

59 Болгоогтун, бибээр дээрээс болой, мөн миний сүр хүч доор оршдог. Бибээр бүхнээс дээгүүр, мөн бүхэнд мөн бүхнээр дамжин мөн бүх зүйлийг “эрж хайдаг бөлгөө, мөн бүх зүйл надад захирагдах тэрхүү өдөр ирэх болно.

60 Болгоогтун, би бол “Альфа ба Омега, бүр Есүс Христ.

50a су Адислах,
Адислагдах,
Адислал.
б су Биенийн үхэл.
51a Иса. 65:20–22;
С ба Г 45:58;
101:29–31.
б су Мянган жил.

в 1 Кор. 15:51–52;
С ба Г 43:32.
53a С ба Г 35:15.
54a Мат. 25:1–13;
С ба Г 45:56–59.
б Мозая 16:2.
55a су Сидней Ригдон.
б су Бардамнал.

56a С ба Г 58:50.
57a С ба Г 18:14–15.
су Номлолын
ажил; Сэрэмжлэх,
Сэрэмжлүүлэг.
б С ба Г 4:3–6.
59a 1 Кор. 2:10.
60a су Альфа ба Омега.

61 Иймийн тул, миний “нэрийг уруулдаа хэрхэн авахад бүх хүмүүн болгоомжлог —

62 Учрыг болгоогтун, энэхүү зэмлэл дор байх тэд Их Эзэний нэрийг хэрэглэх тэд, мөн үүнийг эрх мэдэлгүйгээр дэмий хоосон хэрэглэх тэд олон буйг үнэнээр би хэлнэ.

63 Иймийн тул, сүм нүглүүдээсээ наманчлаг, мөн Их Эзэн бибээр тэднийг эзэмших болно; эс бөгөөс тэд тусгаарлагдах болно.

64 Дээрээс ирдэг тэр нь “ариун нандин бөлгөө, мөн болгоомжтойгоор мөн Сүнсний өдөөлтөөр ^бяригддаг

байх ёстой, мөн үүнд буруушаалт гэж үгүй, мөн та нар Сүнсийг “залбирлаар дамжуулан хүлээн авах болно; иймийн тул, үүнгүйгээр буруушаалт тэнд үлддэг бөлгөө.

65 Миний үйлчлэгчид, Бага Иосеф Смит, Сидней Ригдон хоёр “залбирлаар дамжуулан Сүнсээр тэд заалгуулдгийн дагуу, тэд гэр орныг эрэлхийлэг.

66 Үлэмж илүү мөн мөнхийн “бүрэн дүүрэн ^балдар сууг хүлээн авч болохын тулд иймүүд нь эдгээр зүйлүүдийг тэвчээрээр дамжин дийлэхэд үлдэх болой, эс бөгөөс, илүү их буруушаалт буюу. Амен.

ХЭСЭГ 64

1831 оны есдүгээр сарын 11-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Сүмийн ахлагч нарт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:211–214). Бошиглогч Миссурид байх үедээ хойш тавьсан байсан Библийн орчуулгын талаарх ажлаа сэргээхийн тулд Огайогийн Хайрам уруу шилжихээр бэлтгэж байлаа. Сион (Миссури) уруу аялал хийхээр зарлиг болгуулсан хэсэг ах нар аравдугаар сард явах бэлтгэлээ шаргуу хангаж байлаа. Ийм завгүй үед энэхүү илчлэлт хүлээн авагджээ.

1–11, Илүү их нүгэл тэдэнд үлдэхгүйн тулд Гэгээнтнүүд бие биеэ уучлахаар зарлиг болгогдов; 12–22, Үл наманчлагсад Сүмийн өмнө авчрагдах ёстой; 23–25, Аравны нэгээ төлдөг тэрээр Их Эзэний ирэлтээр шатаагдахгүй байх болно; 26–32, Өрийн эсрэг Гэгээнтнүүд сэрэмжлүүлэгдэв; 33–36, Эсэргүүцэгчид Сионоос тусгаарлагдах

болно; 37–40, Сүм үндэстнүүдийг шүүх болно; 41–43, Сион цэцэглэн хөгжих болно.

БОЛГООГТУН, Ай миний Сүмийн ахлагчид та нар, анхаарагтун та нар мөн сонс, мөн өөрсдийнхөө талаарх миний тааллыг хүлээн авагтун хэмээн та нарын Бурхан Их Эзэн ийн хэлж байна.

61a су Бүдүүлэг үг хэллэг.

64a су Ариун.

б су Хүндэтгэл.

в С ба Г 42:14.

65a су Залбирал.

66a 2 Кор. 4:17.

б Ром 8:18;

С ба Г 58:4; 136:31.

2 Учир нь үнэнээр би та нарт хэлж байна, дэлхийг та нар “дийлэх ёстой хэмээн би хүсдэг; иймийн тул би та нарт ^бөрөвч сэтгэлээр хандана.

3 Та нарын дунд нүгэл үйлдсэн тэд буй; гэвч үнэнээр би хэлнэ, энэ удаад л, өөрийн “алдар суугийн төлөө, мөн бодгалиудын авралын төлөө та нарт нүглүүдийг чинь ^бөршөөсөн билээ би.

4 Бибээр та нарт нигүүлсэнгүй байх болно, учир нь хаант улсыг та нарт өгсөн билээ би.

5 Мөн тэрээр миний “ёслолуудыг дуулгавартай дагахын хэрээр миний өгсөн арга замуудаар дамжуулан түүнийг амьд сэрүүн байхад миний хаант улсын нууцуудын ^бтүлхүүрүүд миний үйлчлэгч Бага Иосеф Смитээс авагдахгүй байх болно.

6 Шалтгаангүйгээр түүний эсрэг далим эрэгч тэд буй;

7 Гэсэн хэдий ч, тэрээр нүгэл үйлдсэн билээ; гэвч үнэнээр би та нарт хэлнэ, нүглүүдээ миний өмнө “хүлээж мөн өршөөлийг хүсдэг, ^бүхэлд хүргэх нүгэл үйлдээгүй тэдэнд Их Эзэн бибээр нүглүүдийг нь “өршөөдөг билээ.

8 Эрт дээр үед, миний шавь нар бие биеийнхээ эсрэг “да-

лим эрж мөн зүрх сэтгэлдээ бие биенээ уучилдаггүй байлаа; мөн энэ хилэнцийн учир тэд зовлонд унаж мөн гашуунаар ^бгэгсгээн цээрлүүлэгддэг байв.

9 Иймийн тул, та нар бие биенээ “уучлах ёстойг та нарт хэлнэ би; учир нь ах дүүгийнхээ зөрчлийг үл ^буучилдаг тэрээр Их Эзэний өмнө буруушаагдахаар зогсох буюу; учир нь түүнд илүү их нүгэл үлддэг болой.

10 Их Эзэн, бибээр өршөөх түүнийгээ би “өршөөх болно, харин бүх хүмүүнийг ^буучлах нь та нараас шаардагдана.

11 Чи бид хоёрын хооронд Бурхан “шүүг, мөн чиний ^бүйлүүдийн дагуу чамайг шагнаг — хэмээн та нар зүрх сэтгэлдээ хэлэх ёстой.

12 Нүглүүдээсээ үл наманчилдаг түүнийг мөн тэдгээрээ үл хүлээдэг түүнийг та нар “сүмийн өмнө авчрах ёстой, мөн судар та нарт өгүүлдгийн дагуу зарлиг буюу илчлэлтийн аль алинаар нь түүнд хандагтун.

13 Мөн Бурхан алдаршиж болохын тулд — та нар өрөвч сэтгэлгүй байж эс уучлахын улмаас бус, харин та нар хуулийн нүдэнд зөвтгөгдөж

64 2a 1 Иохан 5:4.
 б су Өрөвч сэтгэл.
 3a Мосе 1:39.
 б Иса. 43:25.
 5a су Ёслолууд.
 б С ба Г 28:7; 84:19.
 су Санваарын түлхүүрүүд.
 7a Тоол. 5:6–7;
 С ба Г 19:20; 58:43.

су Хүлээн зөвшөөрөх, Хүлээн зөвшөөрөлт.
 б С ба Г 76:31–37.
 в су Уучлах;
 Нүглүүдийн ангижрал.
 8a су Уруу таталт.
 б су Зэмлэх, Зэмлэл.
 9a Марк 11:25–26;

С ба Г 82:1.
 б Мат. 6:14–15;
 Ефес 4:32.
 10a Ег. 33:19;
 Алма 39:6;
 С ба Г 56:14.
 б Мозая 26:29–31.
 11a 1 Сам. 24:12.
 б 2 Тим. 4:14.
 12a С ба Г 42:80–93.

болохын тулд, та нарын хууль тогтоогч болох түүнд та нар гомдохгүй байж болохын тулд үүнийг та нар хийх ёстой —

14 Үнэнээр би хэлнэ, энэ шалтгааны учир та нар эдгээр зүйлүүдийг үйлдэх ёстой.

15 Болгоогтун, Их Эзэн, бибээр өөрийн үйлчлэгч байсан Эзра Буг, мөн тэрчлэн өөрийн үйлчлэгч Исаак Морлейд уур хүрч байлаа, учир нь тэд хуулийг ч, бас зарлигийг ч сахиагүй билээ;

16 Тэд зүрх сэтгэлдээ хилэнцэтийг эрэлхийлдэг байв, мөн Их Эзэн, бибээр Сүнсээ татан авсан билээ. Хилэнц үүнд байгаагүй тэр зүйлийг хилэнц хэмээн тэд “буруушаасан болой; гэсэн хэдий ч, бибээр өөрийн үйлчлэгч Исаак Морлейг өршөөсөн билээ.

17 Мөн тэрчлэн өөрийн үйлчлэгч “Эдвард Партрижийг, болгоогтун, тэрээр нүгэл үйлдсэн авай, мөн “Сатан түүний бодгалийг устгахыг эрэлхийлж буй; харин эдгээр зүйлүүд тэдэнд мэдүүлэгдсэн үед, мөн тэд хилэнцээс наманчилсан үед, тэд өршөөгдөх болно.

18 Мөн эдүгээ, миний үйлчлэгч Сидней Гилберт хэдэн долоо хоногийн дараа ажилдаа мөн Сионы нутаг дахь төлөөний хүний хувиарх

ажил үүрэгтээ эргэж ирэх нь миний хувьд зүйтэй байна гэдгийг үнэнээр би хэлнэ;

19 Мөн тэд мөхөхгүйн тулд түүний харсан хийгээд сонссон тэрхүү зүйл миний шавь нарт мэдүүлэгдэж болох бөлгөө. Мөн энэхүү зорилгын учир би эдгээр зүйлүүдийг ярилаа.

20 Мөн дахин, би та нарт хэлнэ, миний үйлчлэгч Исаак Морлей, тэвчиж чадах зүйлийнхээ дээр “уруу татагдахгүй байж болохын тулд мөн та нарыг эмзэглүүлэхээр бурууг зөвлөхгүйн тулд түүний ферм зарагдах ёстой хэмээх зарлигийг би өгч байна.

21 Миний үйлчлэгч Фредерик Г.Виллямс фермээ зарахыг би үл хүснэ, учир нь Их Эзэн бибээр, Көртландын нутагт таван жилийн хугацаанд хүчирхэг түшицтэй үлдэхийг хүснэ, түүгээр би заримыг нь аварч болохын тулд би ёс бусчуудыг унагаахгүй байх болно.

22 Мөн тэрхүү өдрийн дараа Их Эзэн бибээр, Сионы нутаг өөд явах зүрх сэтгэл нь нээлттэй аливаа “гэмтнийг барьж байх нь үгүй; учир нь Их Эзэн бибээр хүмүүний үрсийн “зүрх сэтгэлийг шаарддаг.

23 Болгоогтун, Хүний Хүүгийн “ирэлтийг хүртэл эдү-

16a 2 Ниф. 15:20;
С ба Г 121:16.
17a су Эдвард
Партриж.

б су Чөтгөр.
20a су Уруу татах,
Уруу таталт.
22a су Гэм.

б Ег. 35:5;
С ба Г 59:15; 64:34.
23a су Есүс Христийн
Хоёр дахь Ирэлт.

гээ энэ нь ^бөнөөдөр хэмээн нэрлэгдэх бөлгөө, мөн үнэнээр энэ нь “золиослолын өдөр, мөн миний хүмүүсийн аравны нэгийг төлүүлэх өдөр бөлгөө; учир нь ^аравны нэгээ төлдөг тэрээр миний ирэлтээр ^бшатаагдах нь үгүй.

24 Учир нь өнөөдрийн дараа тэрхүү “шатаалт ирэх болой—энэ бол Их Эзэний маягаар ярих нь бууу—учир нь үнэнээр би хэлнэ, бүх ^ббардамнагсад хийгээд ёс бусаар үйлдэгч тэд маргааш талбайд хаягдсан сүрэл лугаа адил болох болно; мөн бибээр тэднийг шатаах болно, учир нь бибээр Түмний Их Эзэн билээ; мөн ^аВавилонд үлдсэн хэнийг ч би амь хэлтрүүлэх нь үгүй.

25 Иймийн тул, хэрэв та нар надад итгэх аваас, энэ нь өнөөдөр хэмээн нэрлэгдэж байхад та нар хөдөлмөрлөх болно.

26 Мөн миний үйлчлэгчид, “Ньюел К.Витней мөн Сидней Гилберт эндэх өөрсдийн ^бдэлгүүр хийгээд эзэмшлүүдээ зарах нь зүйд үл нийцэх бөлгөө; учир нь энэ газарт үлдсэн сүмийн үлдэгсэд Сионы нутаг уруу явах хүртэл энэ нь мэргэн ухаан биш болой.

27 Болгоогтун, дайснууддаа “өртэй болох нь миний хуулиудад хориглогдсон, эсвээс хэлэгдсэн бөлгөө;

28 Гэвч болгоогтун, таалах үедээ Их Эзэн авах ёсгүй, мөн түүнд сайн санагдса-наар төл хэмээн ямар ч үед хэлэгдээгүй болой.

29 Иймийн тул, та нар төлөөний хүмүүс учраас та нар Их Эзэний зараалд байгаа бөлгөө; мөн та нар Их Эзэний тааллын дагуу юу ч хийлээ гэсэн Их Эзэний ажил бөлгөө.

30 Мөн тэд Сионы нутагт “өв олж авч болохын тулд тэрээр та нарыг эдгээр эцсийн өдрүүдэд гэгээнтнүүдийнхээ төлөө хангах болголоо.

31 Мөн болгоогтун, Их Эзэн бибээр та нарт тунхаглана, мөн миний “үгс лавтай бөгөөд ^ббиелэгдэхгүй болох нь үгүй, ийнхүү тэд үүнийг олж авах болно.

32 Гэвч бүх зүйл тэдний цаг үед тохиохоор ирэх ёстой.

33 Иймийн тул, сайныг үйлдэхэд “шантрамтгай бүү бай, учир нь та нар агуу ажлын суурийг тавьж байна. Мөн агуу болох тэрхүү зүйл ^бжижиг зүйлүүдээс гарч ирдэг.

23б С ба Г 45:6; 64:24–25.
 в су Золиослол.
 з Малах. 3:10–11.
 су Аравны нэг төлөх, Аравны нэг.
 д Малах. 4:1;
 3 Ниф. 25:1;
 ИС—Т 1:37.
 24а Иса. 66:15–16.
 су Дэлхий—

дэлхийн цэвэршилт;
 Дэлхий—Дэлхийн төгсгөл.
 б Малах. 3:15;
 2 Ниф. 12:12; 23:11.
 су Бардамнал.
 в С ба Г 1:16.
 су Бабел, Вавилон.
 26а су Ньюел

К.Витней.
 б С ба Г 57:8.
 27а су Өр.
 30а С ба Г 63:48.
 31а Марк 13:31;
 2 Ниф. 31:15;
 С ба Г 1:37–38.
 б С ба Г 76:3.
 33а Гал. 6:9.
 б С ба Г 123:16.

34 Болгоогтун, Их Эзэн “зүрх сэтгэл хийгээд эрмэлзэгч оюуныг ^бшаарддаг билээ; мөн эрмэлзэгчид хийгээд ^ддуулгавартнууд эдгээр эцсийн өдрүүдэд Сионы нутгийн сайн сайхныг зооглох болно.

35 Мөн “эсэргүүцэгчид Сионы нутгаас гадагш ^бтусгаарлагдах болно, мөн алсад илгээгдэх болно, мөн уг нутгийг өвлөх нь үгүй.

36 Учир нь эсэргүүцэгчид “Ефраимийн цус биш бөлгөө, иймийн тул, тэд гадагш суга татан хаягдах болно.

37 Болгоогтун, Их Эзэн бибээр үндэстнүүдийг шүүхээр гүвээн дээр эсвээс өндөр газарт суугаа шүүгчийн адилаар эдгээр эцсийн өдрүүдэд өөрийнхөө сүмийг бий болголоо.

38 Учир нь мөнхүү улиран тохиох дор Сионы оршин суугчид Сионд хамаарах бүх зүйлийг “шүүх болно.

39 Мөн худал хэлэгчид хийгээд хоёр нүүртнүүд тэднээр нотлогдох болно, мөн “төлөөлөгчид хийгээд бошиглогчид биш тэд мэдэгдэх болно.

40 Мөн “шүүгч болох ^ббишоп ч, мөн түүний зөвлөхүүд ч, хэрэв тэд “ажил үүрэгтээ итгэлтэй үнэнч биш аваас буруушаагдах болно, мөн тэдний оронд “бусад нь тавагдах болно.

41 Учир нь, болгоогтун, “Сион цэцэглэн хөгжих болно, мөн Их Эзэний ^балдар суу түүн дээр байх болно гэдгийг би та нарт хэлж байна;

42 Мөн тэр нь хүмүүст “туг байх болно, мөн тэнгэрийн доорх үндэстэн бүрээс түүнд ирэх болно.

43 Мөн дэлхийн үндэстнүүд түүний улмаас “дагжин чичрэх тэрхүү өдөр ирэх болно, мөн түүний аймшигтай хүмүүсийн улмаас эмээх болно. Их Эзэн үүнийг ярилаа. Амен.

ХЭСЭГ 65

1831 оны аравдугаар сард Огайогийн Хайрамд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:128). Бошиглогч энэхүү илчлэлтийг залбирал гэж үздэг ажээ.

34a Дэд хууль 32:46;
Иош. 22:5;
Морм. 9:27.
су Зүрх сэтгэл.

б Мика 6:8.

в Иса. 1:19.

су Дуулгавартай байх, Дуулгавартай, Дуулгавартай дагах.

35a су Эсэргүүцэл.

б С ба Г 41:5;

50:8–9; 56:3.

су Сүмээс хөөх.

36a Дэд хууль 33:16–17.

38a Иса. 2:3–4;

С ба Г 133:21.

39a Илч. 2:2.

су Төлөөлөгч.

40a С ба Г 58:17;

107:72–74.

б су Бишоп.

в су Даамал, Ажил үүрэг.

г С ба Г 107:99–100.

41a су Сион.

б С ба Г 45:67;

84:4–5; 97:15–20.

су Алдар суу.

42a су Туг.

43a Иса. 60:14;

С ба Г 97:19–20.

1-2, Бурханы хаант улсын түлхүүрүүд дэлхий дээр хүмүүнд итгэмжлэгдэв, мөн сайн мэдээний зарчим ялан мандах болно; 3-6, Тэнгэрийн мянган жилийн хаант улс ирж мөн дэлхий дээрх Бурханы хаант улсад нэгдэх болно.

АНХААРАГТУН, мөн харагтун, тэнгэрээс доош илгээгдсэн, хүч чадалтай хийгээд хүчтэй нэгний, дэлхийн өнцөг булан бүрд, тийм ээ, дуу хоолой нь хүмүүнд урагш одон — Их Эзэний замыг “бэлтгэгтүн та нар, түүний замуудыг шулуун болгогтун хэмээх түүний дуу хоолойг буюу.

2 Бурханы “хаант улсын” түлхүүрүүд дэлхий дээр хүмүүнд итгэмжлэгдсэн болой, мөн тэндээс сайн мэдээ өвч дэлхийг “дүүргэх хүртлээ гараар урагш өнхрүүлэлгүй уулнаас” таслагдсан чулуу лугаа адил дэлхийн бүх хязгааруудад урагш түгэх болно.

3 Тийм ээ, Их Эзэний замыг бэлтгэгтүн та нар, Хурганы “үдшийн зоогийг бэлтгэгтүн

та нар, “Хүргэн Хүүгийн тулд бэлэн болгогтун — хэмээн хашгирах дуу хоолойг буюу.

4 Их Эзэнд залбирагтун, түүний ариун нэрийг дуудагтун, түүний гайхамшигт ажлуудыг хүмүүсийн дунд мэдүүлэгтүн.

5 Түүний хаант улс дэлхий дээгүүр урагш одож болохын тулд, үүний оршин суугчид үүнийг хүлээн авч болохын тулд Их Эзэнийг дуудагтун, мөн Хүний Хүү “алдар суугийнхаа гялбаанд” хувцаслагдан, дэлхий дээр бий болох Бурханы “хаант улсыг угтахаар тэнгэрт доош” бууж ирэх тэрхүү өдрүүдэд бэлтгэгдэгтүн.

6 Иймийн тул, тэнгэрийн “хаант улс ирж болохын тулд, Ай Бурхан, та тэнгэрт мөн түүнчлэн дэлхий дээр алдаршиж болохын тулд, дайснууд чинь дарагдаж болохын тулд Бурханы “хаант улс урагш одох болтугай; учир нь алдар хүнд, сүр хүч хийгээд алдар суу нь үүрд мөн мөнхөд “таных билээ. Амен.

ХЭСЭГ 66

1831 оны аравдугаар сарын 25-нд Огайогийн Оранжид Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршивой (History

65 1a Иса. 40:3; Мат. 3:3; Иохан 1:23.
2a С ба Г 90:1-5.
б Мат. 16:19;
С ба Г 42:69.
су Санваарын түлхүүрүүд.
в Дуул. 72:19.
су Даниел—

Даниелын Ном;
Эцсийн өдрүүд,
Хожмын өдрүүд.
г Дан. 2:34-45.
3a Мат. 22:1-14;
Илч. 19:9;
С ба Г 58:11.
б су Хүргэн Хүү.
5a су Алдар суу.

б Дуул. 93:1.
в Дан. 2:44.
г Мат. 24:30.
6a Илч. 11:15.
б су Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс.
в Шаст. дээд 29:11;
Мат. 6:13.

of the Church, 1:219–221). Энэ бол чухал чуулганы анхны өдөр байлаа. Энэхүү илчлэлтийн оршилд Бошиглогч бичихдээ, “Виллям Э.МакЛелиний хүсэлтээр, би Их Эзэнээс асууж, мөн дараахыг хүлээн авсан юм” гэжээ (History of the Church, 1:220).

1–4, Үүрдийн гэрээ бол сайн мэдээний бүрэн байдал мөн; 5–8, Ахлагчид номлож, гэрчилж, мөн хүмүүстэй хэлэлцэх ёстой; 9–13, Итгэл бүхий тохинууллын үйлчлэл нь мөнх амьдралыг өвлөх явдлыг хангаж өгдөг.

БОЛГООГТУН, Их Эзэн Бөөрийн үйлчлэгч Виллям Э.МакЛелинд ийн хэлж байна—Алдсуудаасаа чи холдож мөн миний үнэнүүдийг хүлээн авахын хэрээр адислагдсан болой чи, бүр миний нэрэнд “итгэдэг болгон нь буюу хэмээн чиний Гэтэлгэгч, Их Эзэн, дэлхийн Аврагч хэлж байна.

2 Үнэнээр би чамд хэлнэ, тэд “амьдралтай байж мөн эцсийн өдрүүдэд илчлэгдэх ёстой алдар суунуудаас хүртэгчид болгогдож болохын тулд, эрт дээр үед бошиглогчдоор хийгээд төлөөлөгчдөөр энэ нь бичигдсэнчлэн, хүмүүний үрст урагш илгээгдсэн миний ⁶үүрдийн гэрээг мөн бүр миний сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авсны учир адислагдсан болой чи.

3 Миний үйлчлэгч Виллям, би чамд үнэнээр хэлнэ, цэвэр ариун болой чи, гэвч бүгдээр

нь биш; тиймийн тул, миний хараанд үл таалагдах тэдгээр зүйлүүдээсээ наманчлагтун хэмээн Их Эзэн хэлж байна, учир нь Их Эзэн “тэдгээрийг чамд үзүүлэх болно.

4 Мөн эдүгээ, үнэнээр, Их Эзэн бибээр чиний талаар юу хүсдэгээ, эсвээс чиний талаарх миний таалал юу болохыг чамд үзүүлэх болно.

5 Болгоогтун, үнэнээр би та нарт хэлнэ, та нар миний сайн мэдээг нутгаас нутагт, мөн хотоос хотод энэ нь тунхаглагдаагүй байгаа эргэн тойрны нутгуудад та нар “тунхаглах ёстой нь миний таалал юм.

6 Энэ газарт олон өдрөөр бүү үлд; Сионы нутаг оод хараахан бүү яв; харин та нар илгээж чадахынхаа хэрээр, илгээгтүн; өөрөөр, өмч хөрөнгөнийхөө талаар бүү бод.

7 Дорнод нутгууд уруу “явагтун, газар бүрд хүн болгонд мөн тэдний синагогуудад, хүмүүстэй хэлэлцэн ⁶гэрчлэгтүн.

8 Миний үйлчлэгч Самуел Х.Смит чамтай хамт яваг, мөн түүнийг бүү орхи мөн түүнд заавруудаа өгөгтүн; мөн итгэлтэй тэр нь газар

66 1a Иохан 1:12.
су Итгэлтэй байх,
Итгэл.
2a Иохан 10:10;

3 Ниф. 5:13.
б су Шинэ бөгөөд
үүрдийн гэрээ.
3a Иаков 4:7;

Ифер 12:27.
5a Марк 16:15.
7a С ба Г 75:6.
б су Гэрчлэл.

бүрд “хүчирхэг болгогдох болно; мөн Их Эзэн бибээр чамтай хамт явах болно.

9 Өвчтөнүүд дээр “гараа тавигтун, тэгвэл гэд ^бэдгэрэх болно. Их Эзэн бибээр чамайг илгээтэл бүү эргэж ир. Зовлонд тэвчээртэй байгтун. ^аАсуу, тэгвэл та нар хүлээн авах болно, тогш тэгвэл энэ нь та нарт нээгдэх болно.

10 Түүртэхгүй байхыг хичээ. Бүхий л шударга бус явдлыг орхигтун. Чамд муугаар нөлөөлсөн уруу таталт—“садар самууныг бүү үйлд.

11 Эдгээр хэлэгдсэнийг “сахигтун, учир нь эдгээр нь

үнэн бөгөөд итгэгдсэн бөлгөө; мөн чи албан тушаалаа хичээнгүйлэн гүйцэтгэх ёстой, олон хүнийг тэргүүн дээрээ үүрдийн баяр баясгалангийн ^бдуунуудтайгаар ^а“Сион уруу түлхэх ёстой.

12 Бүр эцсийг хүртэл эдгээр зүйлүүдэд “үргэлжлүүл, мөн ач ивээл хийгээд үнэнээр дүүрэн миний Эцэгийн баруун гарт чи мөнх амьдралын ^бтитэмтэй байх болно.

13 Чиний “Бурхан, Их Эзэн, чиний Гэтэлгэгч, бүр Есүс Христ үнэнээр ийн хэлж байна. Амен.

ХЭСЭГ 67

1831 оны арваннэгдүгээр сард Огайогийн Хайрамд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:224–225). Энэ үйл явдал тусгай чуулганых байв, мөн Их Эзэнээс аль хэдийн хүлээн авсан илчлэлтийг хэвлэх явдлыг авч хэлэлцсэн бөгөөд ажилдаа орж байлаа (хэсэг 1-ийн толгой гарчгийг үз). В.В.Фелпс тэдгээрийг Зарлигуудын Ном болгон хэвлэх байсан Индепенденст илчлэлтийн гар бичмэлүүдийг Оливер Каудери, Жон Витмер хоёр авчрах ёстой байв. Ах нараас олон нь тэдэн дээр юүлэгдсэн Ариун Сүнсээр гэрчлэгдсэнээр илчлэлтийг дараа нь эмхтгэл болгон нийтлэх нь яах аргагүй зөв хэмээх чин сэтгэлийн гэрчлэлтэй байлаа. Хэсэг 1 хэмээх тэрхүү илчлэлтийг би хүлээн авсны дараа илчлэлтэд хэрэглэсэн хэлний талаар зарим нэг сөрөг яриа гарсан хэмээн Бошиглогч тэмдэглэсэн байдаг. Уг илчлэлт дор оршвой.

1–3, Их Эзэн өөрийн ахлагчдын залбирлуудыг сонсож мөн харж хамгаалдаг болой; 4–9, Хамгийн мэргэн хүн өөрийнх

нь илчлэлтийн хамгийн багыг нь хуулбарлахаар хичээхийг тэрээр урьдаг; 10–14, Итгэлтэй ахлагчид Сүнсээр амьдруулагдаж

8а С ба Г 52:17; 133:58.
9а су Өвчтөнийг эдгээх; Гар тавих.
б Мат. 9:18.
су Эдгээх, Эдгэрэх.
в Иаков 1:5.
10а су Завхайрал.

11а С ба Г 35:24.
б Иса. 35:10;
С ба Г 45:71.
су Дуулах.
в С ба Г 11:6.
12а 2 Тим. 3:14–15;
2 Ниф. 31:20.

б Иса. 62:3;
Мат. 25:21;
1 Петр 5:4.
13а су Бурхан, Бурхан тэргүүтэн —Хүү Бурхан.

мөн Бурханы нүүрийг харах болно.

БОЛГООГТУН, мөн анхаарагтун, өөрсдийгөө хамтад нь цуглуулсан, залбирлуудыг нь бибээр сонссон, зүрх сэтгэлийг нь бибээр мэдэх, мөн хүслүүд нь миний өмнө ирсэн, Ай миний сүмийн “ахлагчид та нар.

2 Болгоогтун, мөн харагтун, миний “мэлмий та нар дээр байна, мөн тэнгэр хийгээд газар миний гарт байна, мөн өгөгдөх үүрд мөнхийн баялгууд нь минийх болой.

3 Та нарт өргөсөн адислалыг та нар хүлээн авах ёстой гэдэгт та нар итгэхийг хичээлээ; гэвч болгоогтун, та нарын зүрх сэтгэлд “айдсууд байсныг би та нарт үнэнээр хэлнэ, мөн үнэнээр, энэ бол та нар хүлээж аваагүйн шалтгаан болгоо.

4 Мөн эдүгээ, та нарын өмнө тавигдсан эдгээр зарлигуудын үнэний тухай “гэрчлэлийг Их Эзэн бибээр та нарт өгч байна.

5 Та нарын нүд миний үйлчлэгч Бага Иосеф Смит дээр байсаар байна, мөн та нар түүний “хэлийг мэддэг боллоо, мөн түүний төгс бишийг та нар мэддэг боллоо; мөн та нар түүний хэлнээс илүү дээр илэрхийлж болох мэдлэгийг

зүрх сэтгэлдээ та нар эрэлхийлэх боллоо; үүнийг та нар тэрчлэн мэдэх бөлгөө.

6 Эдүгээ, Зарлигуудын Номноос, бүр тэдгээрийн дундаас хамгийн багыг нь эрэлхийлэгтүн та нар, мөн та нарын дунд хамгийн “мэргэн нь болох түүнийг томилогтун;

7 Эсвээс, хэрэв үүнтэй адил нэгийг хийх хэн нэгэн нь та нарын дунд байх аваас, тэгвэл эдгээрийг үнэн гэдгийг та нар мэдэх нь үгүй хэмээн хэлэхэд та нар зөвтгөгдөх болой;

8 Гэвч хэрэв та нар нэгийг нь үүнтэй адил хийж үл чадах аваас, хэрэв та нар тэдгээрийг үнэн хэмээн үл “гэрчилбээс, та нар буруушаалт дор байх бөлгөө.

9 Учир нь тэдгээрт зөв шударга бус зүйл үгүй гэдгийг та нар мэдэх бөлгөө, мөн “зөв шударга нь дээрээс доош, “гэрлүүдийн Эцэгээс ирдэг билээ.

10 Мөн дахин, энэ нь та нарын онцгой боломж гэдгийг үнэнээр би та нарт хэлнэ, мөн та нар өөрсдийгөө “атаа жөтөө хийгээд “айдсаас ангид байлгаж мөн өөрсдийгөө миний өмнө “даруусгахын хэрээр энэхүү тохинуулалд томилогдсон та нар “хөшиг урагдаж мөн намайг “харж намайг байдаг гэдгийг зуур-

67 1a су Ахлагч.

2a Дуул. 34:15.

3a су Айдас.

4a су Гэрчлэл; Үнэн.

5a С ба Г 1:24.

6a 2 Ниф. 9:28–29, 42.

8a су Гэрч.

9a Моро. 7:15–18.

б Иаков 1:17;

С ба Г 50:24; 84:45;

88:49.

10a су Атаархах,

Атаархал.

б су Айдас.

в су Даруу, Даруу байдал.

г су Хөшиг.

д С ба Г 88:68;

93:1; 97:16.

дын ч биш, бас эгэл ч биш, харин сүнслэг оюунаар мэдэх болно хэмээх амлалтыг би та нарт өгч байна, учир нь та нар хангалттай даруу биш байна.

11 Учир нь ямар ч үед Бурханы Сүнсээр амьдруулагдахаас бусдаар Бурханыг махан бодид харсан ямар ч “хүмүүн үгүй бөлгөө.

12 Бас ямар ч “эгэл хүмүүн зуурдын оюунтайгаар Бурханы оршихуйг тэсч чадах нь үгүй.

13 Эдүгээ та нар Бурханы оршихуйд ч, мөн тэнгэр элчүүдийн тохинуулалд ч тэсч чадах нь үгүй; иймийн тул, та нар “төгөлдөржих хүртлээ” тэвчээрт үргэлжлүүл.

14 Оюун тань бүү эргэг; мөн та нар “зохистой байхад миний өөрийн тогтоосон цагт, миний үйлчлэгч Бага Иосеф Смитийн гараар та нар дээр хүртээгдсэн тэрнийг та нар харж мөн мэдэх болно. Амен.

ХЭСЭГ 68

1831 оны арваннэгдүгээр сард Огайогийн Хайрамд Оорсон Хайд, Лук С.Жонсон, Лайман И.Жонсон мөн Виллям Э.МакЛелин нарын хүсэлтээр Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:127–129). Энэхүү илчлэлт нь хэдийгээр нэр дурдсан ахлагчдын талаарх Их Эзэний оюун мэдүүлэгдсэн даруухан залбирлын хариуд өгөгдсөн хэдий ч, агуулгын ихэнх нь нийт Сүмд хамаатай юм.

1–5, Ахлагчдын үгс Ариун Сүнсээр урагш хөдөлгөгдөхөд судар болдог; 6–12, Ахлагчид номлож мөн баптисм хүртээх ёстой, мөн тэмдгүүд үнэн итгэгчдийг дагалдах болно; 13–24, Аароны хөвгүүдийн дундаас ууган нь Тэргүүн Зөвлөлийн удирдлага дор Тэргүүлэх бишопоор (энэ нь ерөнхийлөгчийн зөвлөлийн түлхүүрүүдийг бишопын хувьд атгах явдал мөн) үйлчилж болно; 25–28, Эцэг эхчүүд хүүхдүүддээ

сайн мэдээг заахаар зарлигдуулав; 29–35, Гэгээнтнүүд Хүндэтгэлийн өдрийг чанд мөрдөж, шаргуу хөдөлмөрлөн, мөн залбирдаг байх ёстой.

МИНИЙ үйлчлэгч Оорсон Хайд, түүний томилолтоор үүрдийн сайн мэдээг хүмүүсээс хүмүүст мөн нутгаас нутагт, ёс бусчуудын цугларалтуудад, тэдний синагогуудад тунхаглан, тэдэнтэй

11a исо, Ег. 33:20, 23;
Иохан 1:18; 6:46;
исо, 1 Иохан 4:12;
С ба Г 84:19–22;
Моце 1:11, 14.

12a Мозая 3:19.
су Эгэл хүн.
13a Мат. 5:48;
3 Ниф. 12:48.
б Ром. 2:7.

су Тэвчээр.
14a су Зөв зохистой,
Зөв зохистой
байдал.

хэлэлцэн мөн бүх судрыг ухуулахаар амьд Бурханы “Сүнсээр дуудагдсан байв.

2 Мөн болгоогтун, мөн харагтун, урагш одох нь үүрэг даалгавар болж тэдэнд өгөгдсөн, энэхүү санваарт томилогдсон бүгдэд энэ нь үлгэр жишээ болох ажгуу —

3 Мөн тэд Ариун Сүнсээр урагш хөдөлгөгдөх лугаа адил “ярихын тулд энэ нь тэдэнд үлгэр жишээ болох бөлгөө.

4 Мөн “Ариун Сүнсээр урагш хөдөлгөгдөх тэд юуг ч ярилаа гэсэн судар байх болно, Их Эзэний таалал байх болно, Их Эзэний оюун байх болно, Их Эзэний үг байх болно, Их Эзэний дуу хоолой байх болно, мөн аврал дахь Бурханы ^бсүр хүч буюу.

5 Болгоогтун, энэ бол та нарт өгсөн Их Эзэний амлалт юм, Ай үйлчлэгчид минь.

6 Иймийн тул, зоригтой байгтун, мөн бүү “эмээ, учир нь Их Эзэн бибээр та нартай хамт байна, мөн та нарын дэргэд зогсч байх болно; мөн та нар миний тухай бүр Есүс Христийг, би бол амьд Бурханы Хүү, би байсныг, би байгааг, би байх болно гэдгийг гэрчлэх ёстой.

7 Энэ бол миний үйлчлэгч “Оорсон Хайд чамд, мөн

тэрчлэн миний үйлчлэгч Лук Жонсонд, мөн миний үйлчлэгч Лайман Жонсонд, мөн миний үйлчлэгч Виллям Э.МакЛелинд, мөн миний сүмийн бүх итгэлтэй ахлагчдад хэлсэн Их Эзэний үг болой —

8 Та нарт миний өгсөн тэрхүү “эрх мэдэлд үйлдэн, Эцэг, мөн Хүү, мөн Ариун Сүнсний нэрээр ^ббаптисм хүртээн та нар бүх дэлхий уруу “явагтун, сайн мэдээг “хүн болгонд ^аномлогтун.

9 Мөн итгэдэг хийгээд баптисм хүртсэн “тэр нь ^баврагдах болно, мөн итгэдэггүй тэр нь “яллагдах болно.

10 Мөн итгэдэг тэр нь дагалдагч “тэмдгүүдээр, бүр энэ нь бичигдсэнчлэн, адислагдах болно.

11 Мөн цаг үеийн “тэмдгүүдийг, мөн Хүний Хүүгийн Ирэлтийн тэмдгүүдийг мэдэх нь чамд өгөгдөх болно;

12 Мөн Эцэгийн гэрчлэх болгоны тухайд, тэднийг мөнх амьдралд “тамгалах хүч чамд өгөгдөх болно. Амен.

13 Мөн эдүгээ, гэрээнүүд хийгээд зарлигуудад нэмэлт болох зүйлүүдийн тухайд, тэдгээр нь эдгээр болой —

14 Тэдгээр нь Их Эзэний тогтоосон цагт үүнээс хойш үлдэх бөлгөө; бүр эхнийхийн

68 1a су Ариун Сүнс.

3a 2 Петр 1:21;

С ба Г 18:32;

42:16; 100:5.

4a су Ариун Сүнс;

Илчлэлт.

б Ром 1:16.

6a Иса. 41:10.

7a су Оорсон Хайд.

8a су Эрх мэдэл.

б су Баптисм,

Баптисм хүртээх.

в С ба Г 1:2; 63:37.

г Марк 16:15.

д су Номлолын ажил; Номлох.

9a Марк 16:16;

С ба Г 20:25.

б су Аврал.

в су Ял.

10a су Тэмдэг.

11a су Цаг хугацааны

тэмдгүүд.

12a С ба Г 1:8; 132:49.

су Лацдах,

Лацдалт.

дагуу тохинуулахаар, бусад “бишопууд сүмд онцгойлон адислагдах ёстой;

15 Иймийн тул тэд зохистой “дээд санваартнууд байх ёстой, мөн тэд ⁶Аароны шууд удам биш аваас тэд Мелкезедек санваартны “Тэргүүн Зөвлөлөөр томилогдох ёстой.

16 Мөн хэрэв тэд “Аароны шууд удам байх аваас, хэрэв тэд Аароны хөвгүүдийн дунд ууган нь байх аваас тэд бишопын зөвлөлд хууль ёсны эрхтэй бөлгөө;

17 Учир нь ууганууд нь энэ санваарт ерөнхийлөгчийн зөвлөлийн эрхийг мөн үүний “түлхүүрүүд буюу эрх мэдлийг атгадаг.

18 Энэхүү албан тушаалд, тэрээр Аароны “шууд удам ба ууган нь биш байх аваас энэ санваарын түлхүүрүүдийг атгах хууль ёсны эрх нь ямар ч хүмүүнд үгүй бөлгөө.

19 Гэвч, Мелкизедек санваарын “дээд санваартан нь ⁶бишопын албан тушаалд түүний гүйцэтгэж болох бүх доод албан тушаалуудад албан үүрэг гүйцэтгэх эрх мэдэлтэй учраас Аароны шууд удам байхгүй үед тэрээр Мелкизедек санваартны Тэргүүн Зөвлөлийн гарын дор энэхүү хүчинд дуудагдан мөн онцгойлон адислагдаж мөн томилогдож болно.

20 Мөн тэрчлэн Аароны шууд удам энэхүү Ерөнхийлөгчийн зөвлөлөөр товлогдсон, мөн зохистой мөн “тослон томилсон мөн энэхүү Ерөнхийлөгчийн зөвлөлийн гарын дор ⁶томилогдох ёстой, эс тэгвээс тэд өөрсдийн санваарт албан үүрэг гүйцэтгэх хууль ёсны эрх мэдэлгүй бөлгөө.

21 Гэвч, эцгээс хүүд залгамжлан ирсэн тэдний санваарын эрхийн талаарх тогтоолын ариун журмаар бол, хэрэв тэд ямар ч үед удам угсаагаа нотолж чадах аваас, эсвээс дээр нэрлэгдсэн Ерөнхийлөгчийн зөвлөлийн гарын дор Их Эзэнээс илчлэлт хүлээн авах замаар үүнийг тодорхой болгосноор, тэд өөрсдийн томилолтыг хүсч болно.

22 Мөн дахин, энэхүү тохинууллын тулд онцгойлон адислагдах бишоп буюу дээд санваартан нь сүмийн “Тэргүүн Зөвлөлийн өмнө байхаас бусдаар аливаа гэмт хэрэгт шүүгдэх буюу буруушаагдах ёсгүй;

23 Мөн тэрээр энэхүү Ерөнхийлөгчийн зөвлөлийн өмнө эргэлзээтэй байх аргагүй гэрчлэлээр гэмтэй нь мэдэгдсэн байхын хэрээр тэрээр буруушаагдах ёстой;

24 Мөн хэрэв тэрээр наманчлах аваас тэрээр сүмийн

14a су Бишоп.

15a С ба Г 72:1.

б су Аарон,
Мосегийн ах.

в су Тэргүүн Зөвлөл.

16a С ба Г 107:15–17.

су Аароны

санваар.

17a су Санваарын
түлхүүрүүд.

18a Ег. 40:12–15;

С ба Г 84:18;

107:13–16, 70–76.

19a су Дээд

санваартан.

б су Бишоп.

20a су Томилох.

б су Томилох,

Томилолт.

22a су Тэргүүн Зөвлөл.

гэрээнүүд хийгээд зарлигуудын дагуу “өршөөгдөх болно.

25 Мөн дахин, Сионд эсвээс түүний зохион байгуулагдсан аль ч “гадаснуудад ^бэцэг эхчүүд хүүхдүүдтэй байхын хэрээр, тэдэнд наманчлалын сургаал амьд Бурханы Хүү Христэд итгэх итгэл хийгээд баптисм хүртээх мөн гар тавилтаар ирдэг Ариун Сүсний бэлгийг ойлгохыг тэд “заадаггүй бол, ‘найман нас хүрэхэд, уг ^днүгэл эцэг эхчүүдийнх нь тэргүүн дээр байх болно.

26 Учир нь энэ нь “Сионы оршин суугчдад эсвээс үүний зохион байгуулагдсан аль ч гадаснуудад хууль байх ёстой.

27 Мөн тэдний хүүхдүүд нүглүүдийнхээ “ангжралын тулд ^бнайман настайдаа ^ббаптисм хүртэж, мөн гар тавилтыг хүлээн авах ёстой.

28 Мөн тэд тэрчлэн “залбирахыг, мөн Их Эзэний өмнө цэх шулуун алхахыг хүүхдүүддээ заах ёстой.

29 Мөн Сионы оршин суугчид тэрчлэн “Хүндэтгэлийн өдрийг чанд мөрдөж, үүнийг ариунаар нь сахих ёстой.

30 Мөн Сионы оршин суугчид бүхий л үнэнч шударга байдалд тэд хөдөлмөрлөхөөр томилогдохын хэрээр, өөрсдийн хөдөлмөрүүдийг тэрчлэн санах ёстой; учир нь залхуурагчид Их Эзэний өмнө сануулагдах болно.

31 Эдүгээ, Сионы оршин суугчид Их Эзэн миний таалалд үл нийцнэ, учир нь тэдний дунд “залхуурагчид буй; мөн тэдний хүүхдүүд тэрчлэн ^бёс бус байдалд өсч байна; тэд тэрчлэн үүрд мөнхийн баялгуудыг хичээнгүйлэн “эрэлхийлэх нь үгүй, харин тэдний нүд шуналаар дүүрэн байна.

32 Эдгээр зүйлүүд байх ёсгүй, мөн тэдний дундаас үгүй болгогдох ёстой; иймийн тул, миний үйлчлэгч Оливер Каудери эдгээр хэлэгдсэн үгсийг Сионы нутагт аваачиг.

33 Мөн Их Эзэний өмнө тухайн цагт нь “залбирлуудаа анхаардаггүй тэрээр миний хүмүүсийн шүүлтийн өмнө ^бсануулалтад байг хэмээх нэг зарлигийг бибээр тэдэнд өгч байна.

34 Эдгээр хэлэгдсэн “үгс үнэн бөгөөд итгэмжлэгдсэн

24a су Уучлах.

25a су Гадас.

б су Гэр бүл—Эцэг эхийн хариуцлага.

в су Заах, Багш.

г С ба Г 18:42; 20:71.

д Иаков 1:19;

С ба Г 29:46–48.

26a су Сион.

27a су Нүглүүдийн

ангжрал.

б су Хариуцах,

Хариуцлага,

Хариуцлагатай.

в су Баптисм,

Баптисм хүртээх.

28a су Залбирал.

29a С ба Г 59:9–12.

су Хүндэтгэлийн

өдөр.

31a су Залхуурах,

Залхуу байдал.

б су Ёс бус, Ёс бус

байдал.

в С ба Г 6:7.

33a су Залбирал.

б су Зэмлэх, Зэмлэл;

Шүүх, Шүүлт.

34a Илч. 22:6.

билээ, иймийн тул, тэдгээрийг бүү зөрч, тэрчлэн тэдгээрээс бүү ⁶хас.

35 Болгоогтун, би бол “Альфа ба Омега, мөн бибээр гэнэт ⁶ирнэ. Амен.

ХЭСЭГ 69

1831 оны арваннэгдүгээр сард Огайогийн Хайрамд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:234–235). Илчлэлтийг эмхэтгэл болгон анх удаа нийтлэхээр зорьж байсан нь арваннэгдүгээр сарын 1-ний тусгай чуулган дээр шийдвэрлэгджээ. Энд хэсэг 133 болж орсон уг илчлэлт арваннэгдүгээр сарын 3-нд нэмэгдэж мөн Хавсралт хэмээн нэрлэгджээ. Уг чуулганы үйл ажиллагаагаар Оливер Каудери эмхэтгэсэн илчлэлтүүд болон зарлигуудын гар бичмэлийг хэвлүүлэхийн тулд Миссурийн Индепенденст авч явахаар томилогдсон байжээ. Миссурид Сүм байгуулахын тулд хандивласан мөнгийг тэрээр түүнчлэн авч явах ёстой байв. Аяны зам нь хилийн дагуух хүн ам сийрэг суурьшсан газрыг дайрч өнгөрөх байсан учир, аян замын хамтрагч хүсүүштэй байлаа.

1–2, Жон Витмер Миссури уруу Оливер Каудерийг дагалдан явах ёстой; 3–8, Тэрээр тэрчлэн номлох мөн түүхийн баримтуудыг цуглуулж тэмдэглэн мөн бичих ёстой.

АНХААРАГТУН, намайг, миний үйлчлэгч “Оливер Каудерийн тусын тулд хэмээн Их Эзэн чиний Бурхан хэлж байна. Үнэнч мөн итгэлтэй хэн нэгэн нь түүнтэй хамт эс явбаас, Сионы нутаг уруу түүний аваачих зарлигууд хийгээд мөнгийг түүнд итгэл хүлээлгэсэн байх нь миний хувьд мэргэн ухаан биш бөлгөө.

2 Иймийн тул, Их Эзэн

бибээр, миний үйлчлэгч “Жон Витмер миний үйлчлэгч Оливер Каудеритай хамт явах ёстой хэмээн хүснэ;

3 Мөн тэрээр миний сүмийн талаар ажиглах мөн өөрийн мэдэх бүх чухал зүйлүүдийн “түүхийг бичиж мөн бий болгохоо үргэлжлүүлэх нь буюу;

4 Мөн тэрчлэн тэрээр миний үйлчлэгч Оливер Каудери болон бусдаас “зөвлөгөө хийгээд тусламж хүлээн авах нь буюу.

5 Мөн тэрчлэн дэлхий даяарх миний үйлчлэгчид өөрсдийн “ажил үүргүүдийн тайланг Сионы нутаг уруу урагш илгээх ёстой;

6 Учир нь Сионы нутаг нь

346 С ба Г 20:35; 93:24–25.

35а су Альфа ба Омега. б С ба Г 1:12.

69 1а су Оливер Каудери.

2а су Жон Витмер. 3а С ба Г 47:1–3; 85:1.

4а су Зөвлөгөө.

5а су Даамал, Ажил үүрэг.

эдгээр бүх зүйлийг хүлээн авах мөн гүйцэлдүүлэх байр хийгээд газар нь байх болно.

7 Гэсэн хэдий ч, тэрээр мэдлэгийг илүү хялбархнаар олж авч болохын тулд миний үйлчлэгч Жон Витмер газраас газарт, мөн сүмээс сүмд олон удаа аялаг —

8 Номлон мөн ухуулан, бичиж, хувилж, сонгон авах нь, мөн сүмийн сайн сайхны тулд, мөн “Сионы нутаг дээр өсч өндийх ирээдүй үеийнхний тулд байх бүх зүйлийг олж аван үүнийг үеэс үед, үүрд мөн мөнхөд эзэмшихийн тулд юм. Амен.

ХЭСЭГ 70

1831 оны арваннэгдүгээр сарын 12-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:235–237). Бошиглогчоор бичигдсэн түүх нь арваннэгдүгээр сарын 1-нээс 12-ныг дуустал дөрвөн тусгай чуулган болсныг харуулдаг. Эдгээр цугларалтуудын сүүлчийнхэд нь, хожим нь Сургаал ба Гэрээ хэмээн нэрлэгдсэн Зарлигуудын номны агуу ач холбогдлыг авч үзжээ; мөн үүнийг “эдгээр эцсийн өдрүүдэд Сүмийн суурь, мөн дэлхийд ашиг тус болж, бидний Аврагчийн хаант улсын нууцуудын түлхүүрүүд хүмүүнд дахин итгэл хүлээлгэн өгөгдсөнийг харуулсан болохыг Бошиглогч заан тэмдэглэжээ” (History of the Church, 1:235).

1–5, Илчлэлтийг нийтлэхээр даамлууд томилогдов; 6–13, Сүнслэг зүйлүүдэд хөдөлмөрлөх тэд хөлс шангаа хүртэх нь зүй ёсны юм; 14–18, Гэгээнтэнүүд материаллаг зүйлүүдэд тэгш байх ёстой.

БОЛГООГТУН, мөн анхаарагтун, Ай Сионы оршин суугчид та нар, мөн алс хол байгаа миний сүмийн бүх хүмүүс та нар, мөн бибээр өөрийн үйлчлэгч Бага Иосеф Смит, мөн өөрийн үйлчлэгч Мартин Харрис, мөн тэрчлэн өөрийн үйлчлэгч Оливер Каудери, мөн тэрчлэн өөрийн

үйлчлэгч Жон Витмер, мөн өөрийн үйлчлэгч Сидней Ригдон мөн өөрийн үйлчлэгч Виллям В.Фелпс, тэдэнд зарлигийн замаар өгсөн Их Эзэний үгийг.

2 Учир нь бибээр тэдэнд зарлиг өгсөн билээ; иймийн тул, анхаарагтун, мөн сонс, учир нь Их Эзэн тэдэнд ийн хэлж байна —

3 Их Эзэн, бибээр тэднийг томилсон бөлгөө, мөн тэдэнд миний өгсөн мөн үүнээс хойш тэдэнд миний өгөх илчлэлт хийгээд зарлигуудын “даамлууд байхаар тэднийг томилсон болой;

4 Мөн шүүлтийн өдөр би энэ ажил үүргийн тайланг тэднээс шаардах болно.

5 Иймийн тул, тэдгээрийг хийгээд тэдгээрийн асуудлуудыг зохицуулах, тийм ээ, тэдгээрийн тусын тулд бибээр тэднийг томилсон билээ мөн энэ нь Бурханы сүм дэх тэдний ажил юм.

6 Иймийн тул, тэд эдгээр зүйлүүдийг сүмд ч, мөн дэлхийд ч өгөх ёсгүй хэмээх зарлигийг би тэдэнд өгч байна;

7 Гэсэн хэдий ч, тэд өөрсдийн хэрэгцээ хийгээд өөрсдийн хүсэлд шаардлагатайгаас илүүг хүлээн авахын хэрээр, энэ нь миний “агуулахад өгөгдөх ёстой;

8 Мөн хаант улсын хуулиудын дагуу тэд “өв залгамжлагчид болохын хэрээр, ашиг тус нь Сионы оршин суугчдад мөн тэдний үеийнхэнд ариулан адислагдах болно.

9 Болгоогтун, энэ бол өөрийнх нь “ажил үүрэгт байдаг хүн болгоноос, бүр Их Эзэн бибээр томилсон буюу үүнээс хойш томилох аль ч хүмүүнээс Их Эзэний шаардах тэр зүйл бөлгөө.

10 Мөн болгоогтун, амьд Бурханы сүмд харьяалагдах хэн боловч энэ хуулиас чөлөөлөгдөх нь үгүй;

11 Тийм ээ, бишоп ч, Их Эзэний агуулахын “төлөөний хүн ч, материаллаг зүйлсийн

ажил үүрэгт томилогдсон тэрээр ч үгүй бөлгөө.

12 Сүнслэг зүйлүүдийг эрхлэхээр томилогдсон тэрээр мөн мөнхүү тэрээр бүр материаллаг зүйлсийг эрхлэх ажил үүрэгт томилогдсон тэдний адилаар хөлс шангаа хүртэх нь “зүй ёсны юм;

13 Тийм ээ, илүү элбэг дэлбэгээр, Сүнсний илэрхийллүүдээр дамжин тэдэнд үржин өсөх тэрхүү элбэг дэлбэгээр буюу.

14 Гэсэн хэдий ч, материаллаг зүйлүүддээ та нар “тэгш байх ёстой, мөн энэ нь дурамжхан бус болой, эс тэгвээс Сүнсний илэрхийллүүдийн элбэг дэлбэг байдал татан авагдах болно.

15 Эдүгээ, би энэ “зарлигийг өөрийн үйлчлэгчдэд тэднийг амьд байх үед тэдний ашиг тусын төлөө, тэдний тэргүүн дээрх миний адислалуудын илэрхийллийн төлөө мөн тэдний “хичээл зүтгэлийн шагналын төлөө мөн тэдний аюулгүй байдлын төлөө өгч байна;

16 Хоол хүнс хийгээд “хувцас хунарын тулд; өвийн тулд; орон байрнууд хийгээд газруудын тулд Их Эзэн бибээр ямар ч нөхцөлд тэднийг оруулах болно, мөн Их Эзэн бибээр тэднийг хааш нь ч болов илгээх болно,

17 Учир нь тэд “олон зүйлд

7a С ба Г 72:9–10.
8a С ба Г 38:20.
9a су Даамал, Ажил үүрэг.
11a С ба Г 57:6.

12a Лук 10:7.
14a С ба Г 49:20.
су Өргөл болгох, Өргөлийн хууль.
15a Дэд хууль 10:12–13.

б су Хичээл зүтгэл.
16a С ба Г 59:16–20.
17a Мат. 25:21–23.

итгэлтэй байгаа билээ, мөн тэд нүгэл үйлдээгүйн хэрээр сайныг үйлдсэн билээ.

18 Болгоогтун, Их Эзэн, бибээр “нигүүлсэнгүй болой

мөн тэднийг адислах болно, мөн эдгээр зүйлүүдийн баяр хөөрт тэд орох болно. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 71

1831 оны арванхоёрдугаар сарын 1-нд Огайогийн Хайрамд Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон хоёрт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:238–239). Бошиглогч энэхүү илчлэлтийг хүлээн авагдтал өөрийн бичээч Сидней Ригдоны хамт Библийг орчуулахаа үргэлжлүүлж байлаа, энэ үед үүнийг түр хойш тавьснаар энд өгөгдсөн зааврыг хэрэгжүүлэх нь тэдэнд боломжтой байв. Урвасан Эзра Бутын нийтлүүлсэн сонины зарим өгүүлэгүүдээс болж Сүмийн эсрэг дэгдсэн найрсаг бус санаа бодлуудыг арилгахын тулд ах нар номлохоор явах ёстой байв.

1–4, Иосеф Смит, Сидней Ригдон хоёр сайн мэдээг тунхаглахаар урагш илгээгдэв; 5–11, Гэгээнтнүүдийн дайснууд мэдлуулах болно.

БОЛГООГТУН, миний Бүйлчлэгчид Бага Иосеф Смит мөн “Сидней Ригдон хоёр, та нар миний сайн мэдээг, хаант улсын зүйлүүдийг, бүр миний хүссэнээр та нарт өгөгдөх Сүнсний тэрхүү хэмжээ хийгээд хүчний дагуу ^бтунхаглахаар, тэдгээрийн “нууцуудыг судруудаас тайлбарлахаар та нар амаа нээх ёстой нь надад шаардлагатай хийгээд зүйтэй болсон тэрхүү цаг үнэхээр ирлээ хэмээн Их Эзэн ийн та нарт хэлж байна.

2 Үнэнээр би та нарт хэлнэ,

дэлхийд эргэн тойрныхоо нутгуудад мөн тэрчлэн сүмд, хэсэг хугацаанд, бүр энэ нь та нарт мэдүүлэгдэхийг хүртэл тунхаглагтун.

3 Үнэнээр энэ бол та нарт миний өгч буй түр хугацааны үүрэг даалгавар болой.

4 Иймийн тул, миний талбайд хөдөлмөрлө та нар, дэлхийн оршин суугчдыг дууд, мөн гэрчил, мөн ирэх тэрхүү зарлигууд хийгээд илчлэлтийн замыг бэлтгэгтүн.

5 Эдүгээ, болгоогтун энэ бол мэргэн ухаан болой; унших хэн ч болов тэрээр “ойлгож мөн тэрчлэн ^бхүлээн аваг;

6 Учир нь хүлээн авагч түүнд энэ нь, “элбэг дэлбэгээр, бүр илүү хүчтэйгээр өгөгдөх болно.

7 Иймийн тул, дайснуудаа

18а су Нигүүлсэнгүй, Нигүүлсэл.
71 1а су Сидней Ригдон.

б су Номлолын ажил.
в С ба Г 42:61, 65.
5а су Мэдлэг.

б Алма 12:9–11.
6а Мат. 13:12.

“мадлагтун; тэд та нартай нийтийн өмнө хийгээд ганцаарчлан ⁶уулзахаар тэднийг дуудагтун; мөн та нар итгэлтэй байхын хэрээр тэдний ичгүүртэй байдал илчлэгдэх болно.

8 Иймийн тул, тэд Их Эзэний эсрэг хүчирхэг шалтгаануудаа урагш авчраг.

9 Үнэнээр, Их Эзэн та нарт ийн хэлж байна—та нарын

эсрэг ямар ч “зэвсэг амжилтад хүрэх нь үгүй;

10 Мөн хэрэв хэн нэгэн нь та нарын эсрэг дуу хоолойгоо өргөх аваас, миний өөрийн тогтоосон цагт тэрээр мэдлуулах болно.

11 Иймийн тул, миний зарлигуудыг сахигтун; тэдгээр нь үнэн бөгөөд итгэгдсэн болой. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 72

1831 оны арванхоёрдугаар сарын 4-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:239–241). Хэдэн ахлагч хийгээд гишүүд өөрсдийн үүргийг мэдэх мөн Сүмийн сургаалуудад цаашид гэгээрэхийн тулд цугларав. Энэ хэсэг бол нэг өдөр хүлээн авагдсан хоёр илчлэлтийн эмхэтгэл юм. 1-ээс 8-ыг дуусталх шүлгүүд нь Ньюел К.Витмерт бишопын дуудлагыг нь мэдүүлдэг болой. Тэгээд тэрээр дуудагдаж мөн адислагдсан байв, үүний дараа 9-өөс 26-г дуусталх шүлгүүд хүлээн авагдаж, бишопын үүргүүдэд нэмэлт мэдээлэл өгчээ.

1–8, Ахлагчид ажил үүргийнхээ тайланг бишопт өгч байх ёстой; 9–15, Бишоп агуулах ажиллуулж мөн ядуус хийгээд гачигдагсдыг халамжилдаг; 16–26, Бишопууд ахлагчдын зохистой байдлыг нотлох ёстой.

АНХААРАГТУН, мөн Их Эзэний дуу хоолойг дуулагтун, Ай өөрсдийгөө хамтад нь цуглуулсан, “хаант улс хийгээд хүч та нарт өгөгдсөн, миний сүмийн ⁶дээд санваартнууд та нар.

2 Учир нь үнэнээр ийн Их Эзэн хэлж байна, та нарт, эсвээс сүмд Их Эзэний талбайн энэ хэсэгт та нараас бишоп томилогдох нь “миний хувьд зүйтэй байна.

3 Мөн үнэнээр энэ зүйлд та нар ухаалгаар ажиллалаа, учир нь “даамал бүрийн гарт, ⁶ажил үүргийнх нь “тайланг энэ амьдралд хийгээд үүрд мөнхөд аль алинд нь өгөхийг Их Эзэн шаарддаг бөлгөө.

4 Учир нь итгэлтэй хийгээд энэ амьдралд “ухаалаг тэрээр

7а Мосе 7:13–17.
 б С ба Г 63:37; 68:8–9.
 9а Иса. 54:17.
 72 1а су Бурханы хаант улс буюу Тэнгэ-

рийн хаант улс.
 б С ба Г 68:14–19.
 2а су Бишоп.
 3а су Даамал, Ажил үүрэг.

б Лук 19:11–27.
 в С ба Г 42:32;
 104:11–13.
 4а Мат. 24:45–47.

өөрт нь зориулж Эцэгээс минь бэлтгэсэн ⁶харшуудыг өвлөхөөр зохистойд тооцогдох болой.

5 Үнэнээр би та нарт хэлнэ, миний “талбайн энэ хэсэгт сүмийн ахлагчид ажил үүргийнхээ тайланг миний талбайн энэ хэсэгт надаас томилогдох бишопт үзүүлж байх ёстой.

6 Эдгээр зүйлүүд Сион дахь бишопт гардуулагдахын тулд цэдэгт орох ёстой.

7 Мөн “бишопын үүрэг нь өгөгдсөн зарлигуудаар, мөн чуулганы дуу хоолойгоор мэдүүлэгдэх ёстой.

8 Мөн эдүгээ, үнэнээр би та нарт хэлнэ, миний үйлчлэгч “Ньюел К.Витмер бол энэ хүчинд тавигдаж мөн томилогдох хүн байх ёстой. Энэ бол чиний Бурхан, чиний Гэтэлгэгч Их Эзэний таалал бөлгөө. Бүр тийм буюу. Амен.

9 Их Эзэний үг өгөгдсөн хууль дээр нэмэгдэн, талбайн энэ хэсэгт сүмд томилогдсон бишопын үүргийг мэдүүлэх нь үнэнээр энэ бөлгөө —

10 Их Эзэний “агуулах ажиллуулах; талбайн энэ хэсэгт сүмийн сангуудыг хүлээж авах нь болой;

11 Өмнө нь зарлиг болгогдсончлон ахлагчдын тайланг авах; мөн тэдний хүслүүдэд

“туслах, хүлээн авсныхаа төлөө төлөх тэд, байгаагийнхаа хэрээр төлөх ёстой;

12 Энэ нь тэрчлэн сүмийн сайн сайхны тулд, ядуус хийгээд гачигдагсдын тулд ариулан адислагдаж болох буюу.

13 Мөн “төлөх юмгүй түүний тухайд, тайлан нь аваачигдан мөн гардуулагдах ёстой Сионы бишоп Их Эзэн гарт нь тавих тэрхүү зүйлээс өрийг нь төлөх ёстой.

14 Мөн сүнслэг зүйлүүдэд, сайн мэдээг хийгээд хаант улсын зүйлүүдийг сүмд, мөн дэлхийд гүйцэтгэхэд хөдөлмөрлөдөг итгэлтнүүдийн хөдөлмөрүүд нь Сион дахь бишопт өрийг хариулах ёстой;

15 Ийнхүү энэ нь сүмээс гарах болой, учир нь “хуулийн дагуу Сионд ирэх хүн болгон бүх зүйлийг Сион дахь бишопын өмнө тавих ёстой.

16 Мөн эдүгээ, үнэнээр би та нарт хэлнэ, талбайн энэ хэсэгт ахлагч болгон өөрийн ажил үүргийн тайланг талбайн энэ хэсэг дэх бишопт өгөх ёстой учраас —

17 “Гэрчилгээ нь талбайн энэ хэсэг дэх шүүгч буюу бишопоос хүн бүрийг өвийнхөө хувьд хүлээн зөвшөөрч болохуйц, мөн бүх шаардлагыг хангасан, мөн ухаалаг ⁶даамал

4б С ба Г 59:2.

5а су Их Эзэний талбай.

7а С ба Г 42:31; 46:27; 58:17–18; 107:87–88.

8а су Ньюел

К.Витней.

10а С ба Г 70:7–11; 78:3.

су Агуулах.

11а С ба Г 75:24.

13а су Ядуус.

15а С ба Г 42:30–31.

су Өргөл болгох,

Өргөлийн хууль.

17а С ба Г 20:64, 84.

б С ба Г 42:32.

хийгээд итгэлтэй хөдөлмөрлөгчийн хувьд хүлээн авагдсан болохыг Сион дахь бишопт харуулдаг бөлгөө.

18 Эс тэгвээс тэрээр Сионы бишопоор хүлээн зөвшөөрөгдөх нь үгүй.

19 Мөн эдүгээ ахлагч бүр тэрээр өөрийгөө хийгээд тайлангуудаа бүх зүйлд хүлээн зөвшөөрөгдсөнийг харуулж болохын тулд, өөрийн хөдөлмөрлөдөг сүм буюу сүмүүдээр зөвлөмж болгогдсон байх талбайн энэ хэсэг дэх сүмийн бишопт тайлангаа өгөг хэмээн би та нарт хэлж байна.

20 Мөн дахин, миний сүмийн “бичгийн асуудлууд дээрх даамлуудаар томилогдсон миний үйлчлэгчид бүх зүйлд бишоп буюу бишопуудаас тусламж авах эрхтэй бөлгөө —

21 “Илчлэлт нийтлэгдэж болохын тулд, мөн тэд тэрчлэн сүмд бүх зүйлээр ашиг тустай байх сангуудыг олж авч болохын тулд дэлхийн хязгааруудад урагш одогтун;

22 Тэд тэрчлэн өөрсдийгөө бүх зүйлд хүлээн зөвшөөрөгдсөнийг харуулж болохын тулд, мөн мэргэн даамлууд хэмээн тооцогдохын тулд буюу.

23 Мөн эдүгээ, болгоогтун, ямар ч газарт тэдгээр нь үндэслэн байгуулагдлаа гэхэд, энэ нь миний сүмийн бүх тариуу байрласан салбаруудын хувьд загвар байх ёстой, мөн эдүгээ бибээр айлдваруудаа төгсгөл болгоё. Амен.

24 Хаант улсын хуулиуд дээр, сүмийн гишүүдийн талаар, Сион өөд Ариун Сүнсээр “томилогдсон тэдний мөн Сион өөд ирэх онцгой боломжоор хангагдсан тэдний талаар нэмж хэлэх хэдэн үгс оршвой.

25 Тэд сүмийн гурван ахлагчаас гэрчилгээг, эсвээс бишопоос гэрчилгээг бишопт авч ирэг;

26 Эс тэгвээс Сионы нутаг өөд ирэх тэрээр мэргэн даамал хэмээн эс тооцогдох болно. Энэ нь тэрчлэн загвар болой. Амен.

ХЭСЭГ 73

1832 оны нэгдүгээр сарын 10-нд Огайогийн Хайрамд Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон хоёрт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:241–242). Өмнөх арванхоёрдугаар сарын эхэн үеэс эхлэн Бошиглогч болон Сидней номлоход оролцсоор байв, мөн энэ аргаар Сүмийн эсрэг үүсэн бий болсон тааламжгүй санаа бодлуудыг багасгахад ихийг хийжээ (Хэсэг 71-ийн толгой гарчгийг үз).

20a С ба Г 70:3–5.
21a су Сургаал ба Гэрээ.

24a су Дуудах,
Бурханаас

дуудагдах,
Дуудлага.

1–2, *Ахлагчид номлохоо үргэлжлүүлэх ёстой*; 3–6, *Иосеф Смит, Сидней Ригдон хоёр Библийг дуустал нь орчуулахаа үргэлжлүүлэх ёстой*.

УЧИР нь, “тэд сайн мэдээг номлохоо үргэлжлүүлэх, мөн эргэн тойрныхоо нутгууд дахь сүмүүдэд чуулганыг хүртэл ухуулах ёстой нь миний хувьд зүйтэй байна хэмээн үнэнээр ийн Их Эзэн хэлж байна;

2 Мөн тэгээд, болгоогтун, тэдний хэд хэдэн үүрэг даалгавар тэдэнд, чуулганы “дуу хоолойгоор мэдүүлэгдэх болно.

3 Эдүгээ, миний үйлчлэгчид

Бага Иосеф Смит, Сидней Ригдон та хоёрт үнэнээр би хэлнэ, дахин “орчуулах нь чухал болой хэмээн Их Эзэн хэлж байна;

4 Мөн эргэн тойрны нутгуудад чуулганыг хүртэл боломжийнхоо хэрээр номло; мөн үүний дараа орчуулгын ажлаа дуустал үргэлжлүүлэх нь шаардлагатай байна.

5 Мөн энэ нь цаашдын мэдлэгийг хүртэл, бүр энэ нь бичигдсэнчлэнгээр, ахлагчдад загвар байг.

6 Эдүгээ энэ цагт бибээр та нарт илүүг өгөх нь үгүй. Хормойгоо “шууж мөн хэрсүү байгтун. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 74

1832 оны нэгдүгээр сард *Огайогийн Хайрамд Бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оршвой* (History of the Church, 1:242). Их Эзэний урдахь үгийг [Сургаал ба Гэрээ 73] хүлээн авсны дараа, би Судруудын орчуулгыг дахин эхэлж, мөн нэгдүгээр сарын 25-нд товлосон байсан чуулганы өмнөхөн хүртэл хичээнгүйлэн хөдөлмөрлөв. Энэ үеийн туршид би дараах зүйлийг Коринтын эхний захидлын долдугаар бүлэг, арвандөрөвдүгээр шүлгийн тайлбар болгон хүлээж авсан билээ (History of the Church, 1:242).

1–5, *Мосегийн хуулийг сахихгүй байхыг Паул өөрийнхөө үед Сүмд зөвлөсөн байдаг*; 6–7, *Бага насны хүүхдүүд ариун бөгөөд мөн Цагаатгалаар дамжин ариусгагдсан байдаг*.

УЧИР нь, “үл итгэгч нөхөр нь эхнэрээрээ ариусгагдсан байдаг, мөн үл итгэгч эхнэр нь нөхрөөрөө ариусгагдсан байдаг; тийм биш аваас та нарын хүүхдүүд ариун

73 1а ө.х. Номлолд байсан бусад хүмүүс,
С ба Г 57-68-г үз.
2а С ба Г 20:63.
3а С ба Г 45:60–61; 76:15.

су Иосеф Смитийн Орчуулга (ИСО).
б ө.х. Иосеф Смит, Сидней Ригдон хоёр Библийг орчуулахаа зогсоож

сайн мэдээг номлохоор зарлигдуулав.
6а 1 Петр 1:13.
74 1а 1 Кор. 7:14–19.

биш байх сан, харин эдүгээ тэд ариун юм.

2 Эдүгээ, төлөөлөгчдийн өдрүүдэд хөвч хөндөх хууль Есүс Христийн сайн мэдээнд итгэдэггүй асан бүх иудейчүүдийн дунд байсаар байлаа.

3 Мөнхүү улиран тохиох дор хөвч хөндөх хуулийн талаар хүмүүсийн дунд агуу “зөрчилдөөн үүссэн байв, учир нь хүүхдүүд нь ^бхөвч хөндүүлж мөн гүйцэлдсэн хууль болох Мосегийн “хуульд захирагдахыг үл итгэгч нөхөр хүсдэг байлаа.

4 Мөнхүү улиран тохиох дор, Мосегийн хуулинд захирагдахаар өсгөгдсөн хүүхдүүд эцгүүдийнхээ “уламжлалуудыг дагадаг байв, мөн Есүс Христийн сайн мэдээнд итгэдэггүй байлаа, мөн үүгээр тэд ариун биш болдог байв.

5 Иймийн тул, энэ шалтгааны учир, итгэгч нь үл итгэгчтэй “нэгдэх ёсгүй хэмээх Их Эзэний биш, харин өөрийнхөө зарлигийг төлөөлөгч тэдэнд өгөн; Мосегийн ^бхууль тэдний дундаас үгүй болгогдох ёстой хэмээн сүмд бичжээ,

6 Тэдний хүүхдүүд хөвч хөндүүлэхгүй үлдэж болохын тулд; мөн бяцхан хүүхдүүд ариун бус хэмээх уг уламжлал үгүй болгогдож болохын тулд буюу; учир нь энэ нь иудейчүүдийн дунд тийм байлаа;

7 Гэвч бага насны “хүүхдүүд Есүс Христийн ^бцагаатгалаар дамжин “ариусгагдсан учраас ариун юм; мөн энэ нь судруудын өгүүлдэг тэрхүү утга бөлгөө.

ХЭСЭГ 75

1832 оны нэгдүгээр сарын 25-нд Огайогийн Амхерстад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:242-245). Уг үйл явдал өмнө нь товлогдсон чуулганы үеэр болов. Уг чуулган дээр Иосеф Смит Дээд санваартны ерөнхийлөгчөөр дэмжигдэн мөн томилогдсон байв. Өөрсдийн захиасын ойлголтод хүмүүсийг авчрахад бэрхшээлтэй тулгарсан зарим ахлагчид шууд үүргүүдийнхээ талаар илүү тодорхой мэдэж авахыг хүсч байлаа. Энэхүү илчлэлт ирсэн ажээ.

1-5, Сайн мэдээг номлодог итгэлтэй ахлагчид мөнх амьдралыг олох болно; 6-12, Бүх зүйлийг

заадаг Тайтгаруулагчийг хүлээн авахын тулд залбирагтун; 13-22, Өөрсдийнх нь захиасыг

3а Үйлс 15:1-35;
Гал. 2:1-5.
б су Хөвч хөндөх ёслол.
в су Мосегийн хууль.
4а су Уламжлалууд.
5а су Гэрлэлт,

Гэрлэх—Нэг итгэлтэй хүмүүсийн хоорондох гэрлэлт.
б 2 Ниф. 25:24-27.
7а Моро. 8:8-15;
С ба Г 29:46-47;

137:10.
б су Цагаатгах, Цагаатгал.
в су Аврал— Хүүхдүүдийн аврал.
г су Ариун.

эсэргүүцэгч тэдний шүүлтэд ахлагчид суух болно; 23–36, Номлогчдын гэр бүлүүд Сүмээс тусламж авах ёстой.

ҮНЭНЭЭР, үнэнээр бүр Сүнснийхээ “дуу хоолойгоор яригч бибээр, бүр ^бАльфа ба ^бОмега, чиний Их Эзэн мөн чиний Бурхан би та нарт хэлж байна.

2 Анхаарагтун, миний сайн мэдээг тунхаглахаар, мөн миний “талбайг ^бтайрахаар урагш одохоор нэр нь өгөгдсөн та нар.

3 Болгоогтун, та нар урагш одож мөн үлдэхгүй, мөн “залхуурахгүй байж харин хүч, чадлаараа хөдөлмөрлөх нь миний таалал болой гэдгийг би та нарт хэлнэ —

4 Та нарт миний өгсөн илчлэлт хийгээд зарлигуудын дагуу “үнэнийг ^бтунхаглан дуу хоолойгоо бүрэн дуу мэтээр өргөн.

5 Мөн ийн, хэрэв та нар итгэлтэй байх аваас, та нарт олон “боодол үүрэгдэж, мөн ^балдар хүнд, мөн ^балдар суу, мөн ^бүхэшгүй байдал, мөн ^бмөнх амьдралын ^бтитмийг хүртэх болно.

6 Тиймийн тул, бибээр өөрийн үйлчлэгч Виллям

Э.МкЛелинд үнэнээр хэлнэ, дорнын мужууд уруу явагтун хэмээн түүнд өгсөн даалгавраа би “цуцалж байна;

7 Мөн зүрх сэтгэлийнх нь “бувтналын улмаас түүнийг ^бзэмлэсэн лугаа адил шинэ даалгаврыг Их Эзэн, бибээр түүнд өгч байна;

8 Мөн тэрээр нүгэл үйлдсэн болой; гэсэн хэдий ч, би түүнийг өршөөж, мөн Явагтун чи өмнөд нутгууд уруу хэмээн түүнд дахин хэлж байна.

9 Мөн миний үйлчлэгч Лук Жонсон түүнтэй хамт явж, мөн тэдэнд миний зарлигласан зүйлүүдийг тунхаглаг —

10 Өөрсдөд нь зүйтэй байгаа бүх зүйлийг тэдэнд заах “Тайтгаруулагчийн тулд Их Эзэний нэрийг дуудан —

11 Тэд шантрахгүйн тулд ямагт “залбир; мөн тэд үүнийг хийхийн хэрээр, бүр эцсийг хүртэл би тэдэнтэй хамт байх болно.

12 Болгоогтун, энэ бол та нарын талаарх Бурхан Их Эзэний чинь таалал юм. Бүр тийм буюу. Амен.

13 Мөн дахин, миний үйлчлэгч “Оорсон Хайд мөн миний үйлчлэгч ^бСамуел Х.Смит нар дорнод мужууд

75 1а су Илчлэлт.

б Илч. 1:8.

су Альфа ба Омега.

2а су Их Эзэний талбай.

б Иаков 5:62.

3а су Залхуурах, Залхуу байдал.

4а С ба Г 19:37.

б су Номлолын

ажил.

5а Дуул. 126:6;

Алма 26:5.

б су Хүндэтгэл.

в су Алдар суу.

г су Мөнх бус, Мөнх бус байдал.

д су Мөнх амьдрал.

е су Титэм.

6а С ба Г 66:1–13.

7а су Бувтнах;

Бодлууд.

б су Зэмлэх, Зэмлэл.

10а Иохан 14:26.

су Тайтгаруулагч.

11а 2 Ниф. 32:9.

13а су Оорсон Хайд.

б су Самуел Х.Смит.

уруу аян замдаа гараг, мөн тэдэнд миний зарлигласан зүйлүүдийг тунхаглаг; мөн тэд итгэлтэй байхын хэрээр, харагтун, би тэдэнтэй бүр төгсгөл хүртэл “хамт байх болно.

14 Мөн дахин өөрийн үйлчлэгч Лайман Жонсон, мөн өөрийн үйлчлэгч “Оорсон Пратт нарт тэд тэрчлэн дорнод мужууд уруу аян замдаа гарах ёстой гэдгийг бибээр үнэнээр хэлж байна; мөн болгоогтун, мөн харагтун, бибээр тэрчлэн тэдэнтэй, бүр төгсгөл хүртэл хамт байх болно.

15 Мөн дахин, бибээр өөрийн үйлчлэгч Аса Доддс, мөн өөрийн үйлчлэгч Калвес Вилсон нарт, тэд тэрчлэн өрнөд мужууд уруу аян замдаа гарч, мөн бүр тэдэнд миний зарлигласанчлан, миний сайн мэдээг тунхаглах ёстой хэмээн хэлж байна.

16 Мөн итгэлтэй тэрээр бүх зүйлийг дийлэх болно, мөн эцсийн өдөр “өргөгдөх болно.

17 Мөн дахин, бибээр өөрийн үйлчлэгч Мажор Н.Ашлей, мөн өөрийн үйлчлэгч Бөрр Риггс нарт, тэд тэрчлэн өмнөд мужууд уруу аян замдаа гараг хэмээн хэлж байна.

18 Тийм ээ, тэдэнд миний зарлигласанчлан айлаас айлд, мөн тосгоноос тосгонд, мөн

хотоос хотод тэд бүгдээрээ аян замдаа гараг.

19 Мөн та нар ямар ч айлд орлоо гэсэн тэд та нарыг хүлээн авбал, тэр айлд адислалыг үлдээгтүн, та нар.

20 Мөн ямар ч айлд та нар орлоо гэсэн, мөн тэд та нарыг хүлээн авах нь үгүй бол, та нар тэр айлаас үтэр түргэн холдож явах ёстой, мөн тэдний эсрэг гэрчлэл болгон хөлийнхөө тоосыг “гүвэх ёстой.

21 Мөн та нар “баяр хөөр хийгээд баяраар дүүрэх болно; шүүлтийн өдөр та нар тэр айлын “шүүгчид байж, мөн тэднийг буруушаана гэдгийг, үүнийг мэдэгтүн;

22 Мөн шүүлтийн өдөр үнэн Бурханыг мэддэггүй хүмүүс тэр айлаас илүү тэвчиж болохуйц байх болно; тиймийн тул, хормойгоо “шууж мөн итгэлтэй байгтун, мөн та нар бүх зүйлийг дийлж, мөн эцсийн өдөр өргөгдөх болно. Бүр тийм буюу. Амен.

23 Мөн дахин, өөрсдийнхөө талаарх түүний тааллыг та нар мэдэж болохын тулд нэрс нь өгөгдсөн, Ай миний сүмийн ахлагчид та нар хэмээн Их Эзэн ийн хэлж байна —

24 Болгоогтун, тэдний гэр бүлүүдийг дэмжихэд туслах нь, мөн тэрчлэн сайн мэдээг дэлхийд тунхаглахаар дуудагдах мөн дэлхийд илгээгдэх

13в Мат. 28:19–20.
14а су Оорсон Пратт.
16а С ба Г 5:35.
20а Мат. 10:14;

Лук 10:11–12;
С ба Г 24:15; 60:15.
21а Мат. 5:11–12.
б су Шүүх, Шүүлт.

22а Ефес 6:14;
С ба Г 27:15–18.

шаардлагатай тэдний гэр бүлүүдийг дэмжих нь сүмийн үүрэг болой гэдгийг би та нарт хэлнэ.

25 Иймийн тул, та нарын ахан дүүс зүрх сэтгэлээ нээхэд бэлэн байгаагийн хэрээр та нар гэр бүлдээ зориулж газрууд олж ав хэмээх энэ зарлигийг Их Эзэн бибээр та нарт өгч байна.

26 Мөн ийн гэр бүлдээ газрууд мөн тэдэнд сүмийн дэмжлэгийг олж авч чадах тэд бүгд дорнод уруу ч байна уу, өрнөд уруу ч байна уу, эсвэл умард уруу ч байна уу, эсвэл өмнөд уруу ч байна уу, дэлхийд одох нь бүү бүтэлгүйтэг.

27 Тэд асууг тэгвэл тэд хүлээн авах болно, тогшиг тэгвэл энэ нь тэдэнд нээгдэх болно, мөн тэд хаашаа одох нь дээрээс, бүр “Тайтгаруулагчаар мэдүүлэгдэх болно.

28 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлнэ, “гэр бүлээ⁶ хангах үүрэг хүлээсэн хүн болгон, тэрээр хангаг, мөн ямар ч байдлаар тэрээр титмээ алдах нь үгүй; мөн тэрээр сүмд хөдөлмөрлөг.

29 Хүн болгон бүх зүйлд

“хичээнгүй байг. Мөн тэрээр наманчилж мөн өөрийн замуудыг өөрчлөхгүй бол⁶ залуурагч сүмд байргүй байх болно.

30 Иймийн тул, миний үйлчлэгч Симеон Картер мөн миний үйлчлэгч Эмер Харрис нар тохинуулалд нэгдэг;

31 Мөн тэрчлэн миний үйлчлэгч Эзра Тайре мөн миний үйлчлэгч “Томас Б.Марш хоёр;

32 Мөн тэрчлэн миний үйлчлэгч Хайрум Смит мөн миний үйлчлэгч Рейнолдс Кахун хоёр;

33 Мөн тэрчлэн миний үйлчлэгч Даниел Стантон мөн миний үйлчлэгч Сеймоур Брансон хоёр;

34 Мөн тэрчлэн миний үйлчлэгч Силвестер Смит мөн миний үйлчлэгч Гидеон Картер хоёр;

35 Мөн тэрчлэн миний үйлчлэгч Рагглес Еамес мөн миний үйлчлэгч Стефан Бурнетт хоёр;

36 Мөн тэрчлэн миний үйлчлэгч Майка Б.Велтон мөн тэрчлэн миний үйлчлэгч Еден Смит нар болой. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 76

1832 оны хоёрдугаар сарын 16-нд Огайогийн Хайрамд Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон хоёрт өгөгдсөн үзэгдэл оршвой (History of the Church, 1:245–252). Энэхүү үзэгдлийн цэдгийн оршил болгон Бошиглогч бичихдээ: “Амхерстын чуулганаас эргэж ирснийхээ

27a 2 Ниф. 32:5;
С ба Г 8:2.
су Ариун Сүнс.
28a су Гэр бүл.

б 1 Тим. 5:8;
С ба Г 83:2.
29a су Хичээл зүтгэл.
б су Залхуурах,

Залхуу байдал.
31a су Томас Б.Марш.

дараа би Судруудын орчуулгыг цааш үргэлжлүүлэв. Хүлээн авагдсан өөр өөр илчлэлтээс хүмүүний авралын талаарх олон чухал хэсэг Библиэс авагдсан буюу үүнийг эмхтгэн хэвлэгдэхээс өмнө алга болсон нь илэрхий байлаа. Үлдсэн үнэнүүдээс хэрэв бие махбодид хийгдсэн үйлүүдийнх нь дагуу Бурхан хүн бүрийг шагнадаг байсан аваас, Гэгээнтнүүдийн хувьд мөнхийн гэр нь болох ‘Тэнгэр’ гэдэг нэр томъёо нь нэгээс илүү хаант улсуудыг багтаах учиртай нь илэрхий харагдаж байв. Яг үүнчлэн . . . би өөрөө мөн Ахлагч Ригдон Гэгээнтэн Иоханы Сайн мэдээг орчуулж байхдаа дараах үзэгдлийг харсан билээ” гэжээ (History of the Church, 1:245). Иохан 5:29-ийг орчуулсны дараа энэхүү үзэгдэл Бошиглогчид өгөгдсөн ажээ.

1–4, Их Эзэн бол Бурхан мөн; 5–10, Хаант улсын нууцууд итгэлтэй бүгдэд илчлэгдэх болно; 11–17, Шударга хүмүүс эсвээс шударга бус хүмүүсийн амилуулалтанд бүгд урагш гарч ирэх болно; 18–24, Олон дэлхийн оршин суугчид Есүс Христийн цагаатгалаар дамжин Бурханы төрсөн хөвгүүд мөн охид нь билээ; 25–29, Бурханы тэнгэр элч унаж мөн чөтгөр болсон ажээ; 30–49, Мөхлийн хөвгүүд мөнхийн ялд унах болой; бусад бүгд нь авралын зарим зэрэглэлийг авах бөлгөө; 50–70, Селестиел хаант улсад өргөмжлөгдсөн хүмүүсийн алдар суу хийгээд шагнал дүрслэгдэв; 71–80, Террестиел хаант улсыг өвлөх тэд дүрслэгдэв; 81–113, Теллестиел, Террестиел мөн Селлестиел алдар суунуудад байх тэдний байдал тайлбарлагдав; 114–119, Итгэлтнүүд Ариун Сүнсний хүчээр Бурханы

хаант улсын нууцуудыг харж мөн ойлгож болно.

“СОНСОГТУН, Ай тэнгэрүүд та нар, мөн чих тавигтун, Ай дэлхий, мөн тэдгээрийн оршин суугчид та нар баясан цэнгэгцээ, учир нь Их Эзэн бол ^бБурхан, мөн түүнээс өөр ^аАврагч ^бүгүй бөлгөө.

2 Түүний мэргэн ухаан ^аагуу, түүний замууд ^бер бусын гайхамшигтай ажгуу, мөн түүний үйлүүдийн хэмжээ хязгаарыг хэн ч мэдэж чадах нь үгүй.

3 Түүний ^азорилгууд бүтэлгүйтэх нь үгүй, мөн түүний гарыг зогсоож чадах хэн ч үгүй бөлгөө.

4 Үүрд мөнхөөс үүрд мөнхөд тэрээр ^анэг адил бөлгөө, мөн түүний жилүүд ^бтөгсөх нь хэзээ ч үгүй.

5 Учир нь Их Эзэн ийн хэлдэг — Их Эзэн бибээр надаас

76 1а Иса. 1:2.
б Иер. 10:10.
сү Бурхан, Бурхан тэргүүтэн —ХҮҮ Бурхан.
в сү Аврагч.

г Иса. 43:11;
Хосеа 13:4.
2а 2 Ниф. 2:24;
С ба Г 38:1–3.
б Илч. 15:3.
3а Хаад. дээд 8:56;

С ба Г 1:38; 64:31.
4а Евр. 13:8;
С ба Г 35:1;
38:1–4; 39:1–3.
б Дуул. 102:25–27;
Евр. 1:12.

“эмээдэг тэдэнд ^бнигүүлсэнгүй хийгээд ач ивээлтэй бөлгөө, мөн зөв шударга ёсонд хийгээд үнэнд эцсээ хүртэл надад ^аүйлчилдэг тэднийг хүндэтгэхдээ баяртай байдаг билээ.

6 Тэдний шагнал агуу байх болно, мөн тэдний ^аалдар суу мөнхөд байх болно.

7 Мөн бибээр тэдэнд бүх ^анууцыг тийм ээ, эрт дээр үеэс нууцлаг байсан хаант улсынхаа бүх нууцыг ^билчлэх болно, мөн ирэх үеүдэд, хаант улсдаа хамаарах бүх зүйлийн талаарх өөрийн тааллыг сайн таашаалыг би тэдэнд мэдүүлэх болно.

8 Тийм ээ, бүр үүрд мөнхийн гайхамшгуудыг тэд мэдэх болно, мөн ирэх тэр зүйлүүдийг, бүр олон үеийн зүйлүүдийг би тэдэнд үзүүлэх болно.

9 Мөн тэдний ^амэргэн ухаан агуу байх болно, мөн тэдний ^бойлголт тэнгэрт тулах бөлгөө, мөн тэдний өмнө ухаантнуудын мэргэн ухаан ^амөхөх болно, мөн хэрсүү ухаантнуудын ойлголт юу ч биш болно.

10 Учир нь бибээр ^аСүнсээр тэднийг ^бгэгээрүүлэх болно,

мөн бибээр өөрийн ^асүр хүчээр тааллынхаа нууцуудыг тэдэнд мэдүүлэх болно—тийм ээ, бүр ^внүд хараагүй, чих сонсоогүй, хүмүүний зүрх сэтгэлд ороогүй тэдгээр зүйлүүдийг буюу.

11 Бага Иосеф Смит, Сидней Ригдон бид хоёр манай Их Эзэний нэг мянга найман зуун гучин хоёр онд, хоёрдугаар сарын арван зургаа дахь өдөр ^аСүнсэнд байснаар—

12 ^аСүнсний хүчээр бидний ^бнүд нээгдэж мөн бидний ойлголтууд гэгээрүүлэгдсэн бөлгөө, тийнхүү Бурханы зүйлүүдийг харж мөн ойлгоход хүрсэн буюу—

13 Бүр ^аэхлэлээс Эцэгийн цээжинд байсан түүний Төрсөн Ганц Хүүгээр дамжуулан Эцэгийн томилсон бүр дэлхий байхаас өмнө эхлэлээс байсан тэдгээр зүйлүүдийг буюу;

14 Түүний тухай бид гэрчилдэг; мөн бидний гэрчлэх тэрхүү гэрчлэл нь Хүү болох түүнийг бид харж мөн тэнгэрлэг ^аүзэгдэлд бид түүнтэй ^бярилцсан Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдал бөлгөө.

15 Учир нь Их Эзэнээс

5а Дэд хууль 6:13;

Иош. 4:23–24.

су Айдас;

Хүндэтгэл.

б Ег. 34:6; Дуул. 103:8.

су Нигүүлсэнгүй,

Нигүүлсэл.

в С ба Г 4:2.

6а су Селестиел

алдар суу.

7а су Бурханы

нууцууд.

б С ба Г 42:61; 59:4;

98:12; 121:26–33.

9а су Мэргэн ухаан.

б су Мэдлэг.

в Иса. 29:14;

2 Ниф. 9:28–29.

10а Моро. 10:5.

б су Илчлэлт;

Гэрчлэл.

в су Хүч.

г Иса. 64:4;

1 Кор. 2:9;

3 Ниф. 17:15–17;

С ба Г 76:114–116.

11а Илч. 1:10.

12а су Зөөгдөлт.

б С ба Г 110:1; 137:1;

138:11, 29.

13а Мосе 4:2.

14а су Үзэгдэл.

б С ба Г 109:57.

бидэнд тохоон томилсон “орчуулгын ажлыг бид хийж байх үед бидэнд өгөгдсөн Иоханы тавдугаар бүлгийн хорин есдүгээр шүлэгт бид хүрч ирсэн нь дараах байдлаар ажгуу—

16 Хүний “Хүүгийн дуу хоолойг ⁶сонсох тэдний тухай нас барагсдын амилуулалтын талаар өгүүлсэн нь:

17 Булшинд байгчид бүгдээрээ; “сайныг үйлдсэн тэд, ⁶шударга хүмүүсийн “амилуулалтад, мөн хилэнцэтийг үйлдсэн тэд, шударга бус хүмүүсийн амилуулалтад түүний дуу хоолойг сонсон мөн урагш гарч ирэх болно.

18 Эдүгээ энэ нь биднийг гайхахад хүргэв, учир нь энэ нь Сүнснээс бидэнд өгөгдсөн байв.

19 Мөн бид эдгээр зүйлүүдийг “бясалгаж байх үед, Их Эзэн бидний ойлголтын мэлмийд хүрч мөн тэдгээр нь нээгдсэн болой, мөн Их Эзэний алдар суу эргэн тойронд гийж байв.

20 Мөн “Эцэгийн ⁶баруун гар дахь Хүүгийн “алдар сууг

бид болгоож, мөн түүний бүрэн байдлыг хүлээн авсан буюу;

21 Мөн, Бурханыг мөн Хургыг сэнтийнийх нь өмнө “шүтэн биширч буй мөн түүнийг үүрд хийгээд мөнхөд шүтэн биширдэг ариун ⁶тэнгэр элчүүдийг мөн “ариусгагдсан хүмүүсийг харав.

22 Мөн эдүгээ, түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол түүний талаар бидний өгөх, хамгийн сүүлчийн “гэрчлэл юм: Тэр ⁶амьд бөлгөө!

23 Учир нь бид түүнийг бүр “Бурханы баруун гар талд ⁶харсан билээ; түүнчлэн тэрээр Эцэгийн “Төрсөн Ганц болой хэмээн гэрчлэх дуу хоолойг бид сонссон билээ—

24 Ийнхүү “түүгээр, мөн түүгээр дамжин, мөн түүнээс, ⁶дэлхийнүүд бүтээгдсэн мөн бүтээгддэг ажгуу, мөн тэдгээрийн оршин суугчид нь Бурханы төрсөн “хөвгүүд хийгээд охид нь бөлгөө.

25 Мөн Эцэгийн дэргэд эрх мэдэлд байсан Бурханы нэг “тэнгэр элч асан тэрээр, Эцэг

15a су Иосеф Смитийн Орчуулга (ИСО).

16a су Хүний Хүү.
б Иохан 5:28.

17a су Ажлууд.
б Үйлс 24:15.

в су Амилуулалт.

19a су Тунгаан бодох.

20a су Бурхан, Бурхан тэргүүтэн —Эцэг Бурхан.

б Үйлс 7:56.

в су Есүс Христ—
Есүс Христийн

алдар суу.

21a су Шүтэн бишрэх.

б Мат. 25:31;

С ба Г 130:6–7; 136:37.

в су Ариусгал.

22a су Гэрчлэл.

б С ба Г 20:17.

23a су Бурхан, Бурхан тэргүүтэн —Эцэг Бурхан.

б су Есүс Христ—
Христийн мөнх бус амьдралын дараах ирэлт.

в Иохан 1:14.

су Төрсөн Ганц.

24a Евр. 1:1–3;

3 Ниф. 9:15;

С ба Г 14:9; 93:8–10.

б Мосе 1:31–33; 7:30.

су Бүтээх, Бүтээл.

в Үйлс 17:28, 29;

Евр. 12:9;

су Бурханы

хөвгүүд охид.

25a С ба Г 29:36–39;

Мосе 4:1–4.

су Чөтгөр.

хайрладаг байсан, мөн Эцэгийн цээжинд байсан Төрсөн Ганц Хүүгийн эсрэг бослого гаргаж, Эцэг мөн Хүүгийн дэргэдээс доош хаягдсаныг бид тэрчлэн харсан билээ, мөн гэрчилж байна,

26 Мөн Мөхөл хэмээн нэрлэгддэг байв, учир нь тэнгэр түүнээс болж уйлсан ажээ, тэр бол “Люсифер, өглөөний хүү байв.

27 Мөн бүр өглөөний хүү тэрбээр “унасан! унасныг бид болгоов, мөн харагтун!

28 Мөн биднийг Сүнсэнд байхад, бид уг үзэгдлийг бичих ёстой хэмээн Их Эзэн бидэнд зарлиглав; учир нь Бурханы эсрэг “бослого гаргасан, Сатан, хөгшин ^бхорт могой, бүр ^ччөтгөрийг бидний Бурханы болон түүний Христийн хаант улсыг авахаар эрэлхийлснийг бид болгоов—

29 Иймийн тул, тэрээр Бурханы гэгээнтнүүдтэй “дайтдаг, мөн тэднийг тойрон бүсэлдэг ажгуу.

30 Мөн түүний дайтаж мөн түүний дийлсэн тэдний зовлонгуудын тухай үзэгдлийг бид харав, учир нь ийн Их Эзэний дуу хоолой бидэнд ирсэн болой:

31 Миний сүр хүчийг мэддэг,

мөн үүнийг хүртэгсэд болгогдсон, мөн чөтгөрийн хүчээр дамжин өөрсдийгөө “ялагдсан байхыг, мөн үнэнийг үгүйсгэхийг хийгээд миний хүчийг эсэргүүцэхийг зөвшөөрсөн тэд бүгдийн талаар ийн Их Эзэн хэлдэг ажгуу—

32 Тэд бол “мөхлийн ^бхөвгүүд болох тэд болой, тэд огт төрөөгүй байсан бол дээр байх сан хэмээн би тэдний тухайд хэлдэг;

33 Учир нь тэд бол үүрд мөнхөд чөтгөр хийгээд түүний элчүүдтэй хамт Бурханы хилэгнэлд зовж байдаг муу заяатай, хилэгнэлийн савнууд юм;

34 Энэ дэлхийд ч, ирэх дэлхийд ч “өршөөл үгүй хэмээн би тэдний талаар хэлсэн бөлгөө—

35 Ариун Сүнсийг хүлээн авсныхаа дараа үүнийг “үгүйсгэсний учир мөн Эцэгийн Төрсөн Ганц Хүүг үгүйсгэсний учир, түүнийг оюун санаандаа ^бцовдолж мөн түүнийг нийтийн өмнө ичгүүрт тавьсны учир бөлгөө.

36 Эдгээр нь чөтгөр хийгээд түүний элчүүдийн хамт галт болон хүхэрт “нуур уруу очих тэд болой—

26a Иса. 14:12–17.
су Люсифер.

27a Лук 10:18.

28a су Тэнгэр дэх дайн.
б Илч. 12:9.

в су Чөтгөр.

29a Илч. 13:7;

2 Ниф. 2:18; 28:19–23.

31a су Урвалт.

32a С ба Г 76:26;
Моце 5:22–26.

б су Мөхлийн
хүүхдүүд.

34a Мат. 12:31–32.
су Уучлах.

35a 2 Петр 2:20–22;
Алма 39:6.

су Уучлагдашгүй

нүгэл.

б Евр. 6:4–6;

1 Ниф. 19:7;

С ба Г 132:27.

36a Илч. 19:20; 20:10;
21:8;

2 Ниф. 9:16; 28:23;

Алма 12:16–18;

С ба Г 63:17.

37 Мөн хоёр дахь “үхэл тэдэн дээр хүчтэй байх гагцхүү тэд болой;

38 Тийм ээ, үнэнээр, түүний хилэгнэлийн зовлонгуудын дараа, Их Эзэний тогтоосон цагт гэтэлгэгдэх нь үгүй гагцхүү “тэд болой.

39 Учир нь үлдсэн бүгд нь, дэлхийнүүд хийгдэхээс өмнө Эцэгийн цээжинд байсан, егүүтгэгдсэн “Хурганы алдар суу хийгээд ялгуусан баяраар дамжин нас барагсдын ^бамилуулалтаар “урагш авчрагдах болно.

40 Мөн энэ бол тэнгэрээс гарах дуу хоолой нь бидэнд гэрчилсэн, “сайн мэдээ, баярт мэдээнүүд бөлгөө —

41 Ийнхүү тэрээр, бүр Есүс, дэлхийн төлөө “цовдлогдохоор, мөн ^бдэлхийн нүглүүдийг “үүрэхээр, мөн дэлхийг ^вариусгахаар, мөн үүнийг бүхий л шударга бус явдлаас нь ^дцэвэрлэхээр дэлхийд ирсэн бөлгөө;

42 Ийнхүү Эцэгийн, түүний хүчинд тавьсан мөн түүгээр хийгдсэн тэд бүгд түүгээр дамжин бүгдээрээ “аврагдаж болох бөлгөө;

43 Тэрээр Эцэгийг алдар-

шуулж мөн Хүүг Эцэг илчилсний дараа түүнийг үгүйсгэдэг мөхлийн хөвгүүдээс бусад түүний гарын бүх ажлыг тэрээр авардаг бөлгөө.

44 Иймийн тул, тэднээс бусдыг нь тэрээр бүгдийг авардаг билээ—төгсгөлгүй шийтгэл болох, мөнхийн шийтгэл болох, “үүрдийн ^бшийтгэл уруу, тэдний тарчлал болох ^вөт хорхой нь үхэхгүй, мөн гал нь унтрахгүй тэнд ^гчөтгөр хийгээд түүний элчүүдтэй хамт тэд үүрд мөнхөд хаанчлахаар очих болно—

45 Мөн үүний “төгсгөлийг ч, мөн үүний газрыг ч, мөн тэдний тарчлалыг ч ямар ч хүмүүн мэдэх нь үгүй;

46 Үүнийг хүртэгчид болгогдсон тэднээс бусад хүмүүнд энэ нь илчлэгдэж байгаагүй, одоо ч илчлэгдээгүй, мөн илчлэгдэх нь ч үгүй билээ;

47 Гэсэн хэдий ч Их Эзэн бибээр үүнийг үзэгдлээр олонд нь үзүүлэх боловч үүнийг дахин тэр даруй хаадаг билээ;

48 Иймийн тул, үүний төгсгөл, өргөн, өндөр, “гүнийг, мөн гуниг зовлонг тэд, мөн

37a су Сүнсний үхэл.
38a су Мөхлийн хүүхдүүд.
39a су Есүс Христ.
б су Амилуулалт.
в өх Гэтэлгэгдэх, 38-р шүлгийг үз. Бүгд амилуулагдах болно.
Алма 11:41-45-г үз.
су Амилуулах.

40a 3 Ниф. 27:13–22.
су Сайн мэдээ;
Гэтэлгэлийн төлөвлөгөө.
41a су Цовдлуулалт.
б 1 Иохан 2:1–2.
в Иса. 53:4–12;
Евр. 9:28.
г су Ариусгал.
д су Гэтэлгэх,
Гэтэлгэгдэх,

Гэтэлгэл.
42a су Аврал.
44a С ба Г 19:6–12.
б су Ял.
в Иса. 66:24;
Марк 9:43–48.
г су Чөтгөр.
45a С ба Г 29:28–29.
48a Илч. 20:1.

энэхүү ^ббуруушаалтад ^атомилогдсон тэднээс бусад ямар ч хүн ойлгох нь үгүй.

49 Мөн дуу хоолой: Үзэгдлийг бичигтүн, учир нь харагтун, энэ бол бурханлиг бусчуудын зовлонгуудын тухай үзэгдлийн төгсгөл болой хэмээн өгүүлэхийг бид сонсов.

50 Мөн дахин бид гэрчилж байна—учир нь бид харж мөн сонссон болой, мөн энэ бол шударга хүмүүсийн ^аамилуулалтад урагш гарч ирэх тэдний талаарх Христийн сайн мэдээний ^бгэрчлэл болой—

51 Тэд бол Есүсийн тухай гэрчлэлийг хүлээн авсан, мөн түүний нэрэнд ^аитгэсэн, мөн түүний оршуулгын ^бмаягаар ^вбаптисм хүртсэн, түүний нэрээр усанд ^горшуулагдсан тэд болой, мөн энэ нь түүний өгсөн тэрхүү зарлигийн дагуу буюу—

52 Тийнхүү тэд зарлигуудыг сахиснаар бүх нүглээсээ

^аугаагдаж мөн ^бцэвэршигдэн мөн энэ ^вхүчинд ^гтомилогдон мөн лацдагдсан түүнээс ^дгар тавилтаар Ариун Сүнсийг хүлээн авч болох ажгуу;

53 Мөн итгэлээр дийлж, мөн шударга хийгээд үнэнч тэд бүгдийн дээр Эцэгийн цутгадаг амлалтын ^аАриун Сүнсээр ^блацдагдсан тэд буюу.

54 Тэд бол ^аУуган Хүүгийн сүм болох тэд бөлгөө.

55 Тэд бол Эцэг ^абүх зүйлийг гарт нь өгсөн тэд буюу—

56 Тэд бол түүний бүрэн байдлыг, мөн түүний алдар сууг хүлээн авсан ^асанваартнууд хийгээд хаад болох тэд болой;

57 Мөн Төрсөн Ганц Хүүгийн ^ажаягийн дагуу байсан ^бЕнохын жаягийн дагуу байсан Мелкизедекийн жаягийн дагуух Бүхний Дээдийн ^всанваартнууд бөлгөө.

58 Иймийн тул, энэ нь бичигдсэнчлэн, тэд бол ^абурхад, бүр ^бБурханы ^вхөвгүүд бөлгөө—

48б Алма 42:22.

^в ө.х. Шийтгүүлэх,
Хүргэгдэх.

50а су Амилуулалт.

^б су Гэрчлэл.

51а С ба Г 20:25–27, 37.

^б С ба Г 128:13.

^в су БAPTИСМ,
БAPTИСМ хүртээх.

^г Ром. 6:3–5.

су БAPTИСМ,
БAPTИСМ хүртээх—
Умбуулах баптисм.

52а 2 Ниф. 9:23;

Моро. 8:25–26.

^б су Цэвэр ариун,
Цэвэр ариун
байдал.

^в су Эрх мэдэл.

^г су Томилох,
Томилолт.

^д су Ариун Сүнсний
бэлэг; Гар тавих.

53а Ефес 1:13;

С ба Г 88:3–5.

су Амлалтын
Ариун Сүнс.

^б су Лацдах,
Лацдалт.

54а Евр. 12:23;

С ба Г 93:21–22.

су Анх төрсөн.

55а 2 Петр 1:3–4;

С ба Г 50:26–28;
84:35–38.

56а Ег. 19:6;

Илч. 1:5–6; 20:6.

57а С ба Г 107:1–4.

^б Эхл. 5:21–24.

су Енох.

^в су Санваартан,
Мелкизедек
санваар.

58а Дуул. 82:1, 6;
Иохан 10:34–36.

су Хүмүүн,
Хүмүүс—Хүн,
Тэнгэрлэг Эцэгтэй

адил болох боломж.

^б С ба Г 121:32.

су Бурхан, Бурхан
тэргүүтэн.

^в су Бурханы
хөвгүүд охид.

59 Иймийн тул, “бүх зүйл тэднийх болой, амьдрал эсвээс үхэл, эсвээс одоогийн зүйлүүд, эсвээс ирэх зүйлүүд, бүгд тэднийх болой мөн тэд бол Христийнх, мөн Христ нь Бурханых бөлгөө.

60 Мөн тэд бүх зүйлийг “дийлэх болно.

61 Иймийн тул, хүмүүнд хүмүүн бүү “алдаршиг, харин бүх дайсныг хөл дороо захирах Бурханыг тэрбээр “алдаршуулаг.

62 Эдгээр нь Бурхан хийгээд түүний Христийн “дэргэд үүрд мөн мөнхөд “орших болно.

63 Эдгээр нь тэрээр газар дэлхий дээр өөрийн хүмүүст “хаанчлахаар тэнгэрийн үүлэнд “ирэхдээ, өөртэйгөө хамт авчрах “тэд бөлгөө.

64 Эдгээр нь “анхны амилуулалтад хувьтай байх тэд болой.

65 Эдгээр нь шударга хүмүүсийн “амилуулалтад урагш гарч ирэх тэд бөлгөө.

66 Эдгээр нь “Сион “Уул

уруу мөн амьд Бурханы хот уруу, тэрхүү тэнгэрлэг, бүхнээс хамгийн ариун газар уруу очих тэд болой.

67 Эдгээр нь тоо томшгүй олон тэнгэр элч уруу ерөнхий хуралдайд мөн “Енохын сүмд мөн “Ууган Хүүгийн сүмд ирэх тэд бөлгөө.

68 Эдгээр нь Бурхан хийгээд Христ бүхний “шүүгч байдаг тэнгэрт нэр нь “бичигдсэн тэд буюу.

69 Эдгээр нь өөрийнхөө “цус урсгалтаар дамжуулан энэхүү төгс “цагаатгалыг хийсэн, шинэ “тэрээний зууч Есүсээр дамжин “төгс болгогдсон “шударга хүмүүс болох тэд бөлгөө.

70 Эдгээр нь бие махбодь нь “селестиел, “алдар суу нь “нарных, бүр бүхнээс хамгийн дээд, алдар суу нь огторгуйд ердийн байдаг нар лугаа адил хэмээн бичигдсэн Бурханы алдар суу болой.

71 Мөн дахин, “террестриел дэлхийг бид үзэв, мөн болгоогтун мөн харагтун,

59a Лук 12:42–44;
3 Ниф. 28:10;
С ба Г 84:36–38.

60a Илч. 3:5; 21:7.

61a Иохан 5:41–44;

1 Кор. 3:21–23.

б С ба Г 49:6.

в 2 Ниф. 33:6;

Алма 26:11–16.

су Алдар суу.

62a С ба Г 130:7.

су Мөнх амьдрал.

б Дуул. 15:1–3; 24:3–4;

1 Ниф. 15:33–34;

Моце 6:57.

63a С ба Г 58:22.

су Есүс Христ—

Христийн Мянган

жилийн хаанчлал.

б Мат. 24:30.

в С ба Г 88:96–98.

су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

64a Илч. 20:6.

65a су Амилуулалт.

66a су Сион.

б Иса. 24:23;

Евр. 12:22–24;

Илч. 14:1;

С ба Г 84:2; 133:56.

67a С ба Г 45:9–12.

б Евр. 12:23;

С ба Г 76:53–54.

су Анх төрсөн.

68a су Есүс Христ—

Шүүгч.

б су Амьдралын
Ном.

69a су Цус.

б су Цагаатгах,

Цагаатгал.

в су Шинэ бөгөөд

үүрдийн гэрээ.

г Мор. 10:32–33.

д С ба Г 129:3; 138:12.

70a С ба Г 88:28–29;

131:1–4; 137:7–10.

су Селестиел

алдар суу.

б С ба Г 137:1–4.

в Мат. 13:43.

71a С ба Г 88:30.

су Террестриел

алдар суу.

тэдгээр нь террестриелийнх болох тэд бөлгөө, тэдний алдар суу нь Эцэгийн бүрэн байдлыг хүлээн авсан Ууган Хүүгийн сүмийнхээс, бүр огторгуй дахь нарнаас ^бсар ялгардгийн адил ялгарах авай.

72 Болгоогтун, эдгээр нь “хуульгүйгээр нас барсан тэд бөлгөө;

73 Мөн тэрчлэн тэд бол хүмүүсийн “шоронд хоригдсон ^бсүнснүүд бөгөөд тэд махан бодь дахь хүмүүний дагуу шүүгдэж болохын тулд Хүү тэдэнд айлчилж ирэн, мөн ^бсайн мэдээг тэдэнд ^вномложээ;

74 Тэд Есүсийн тухай “гэрчлэлийг махан бодид хүлээн аваагүй, харин хожим нь үүнийг хүлээн авсан ажээ.

75 Эдгээр нь хүмүүний башир аргаар харалган болсон дэлхийн шударга сайн хүмүүс юм.

76 Эдгээр нь түүний бүрэн байдлыг бус, харин түүний алдар сууг хүлээн авсан тэд юм, гэвч.

77 Эдгээр нь Эцэгийн бүрэн байдлыг бус харин Хүүгийн оршихуйг хүлээн авсан тэд юм.

78 Иймийн тул, тэд бол селестиел биес бус террестриел “биес бөгөөд нарнаас

сар ялгардаг шиг алдар сууд ялгардаг билээ.

79 Эдгээр нь Есүсийн тухай гэрчлэлд нэн “хүчтэй биш тэд бөлгөө; иймийн тул, бидний Бурханы хаант улс дээрх титмийг тэд олж авах нь үгүй.

80 Мөн эдүгээ энэ нь террестриелчүүдийн талаар бидний харсан, биднийг Сүнсэнд байх зуур үүнийг бичихийг Их Эзэн бидэнд зарлигласан үзэгдлийн төгсгөл бөлгөө.

81 Мөн дахин, бүр огторгуй дахь сарны алдар суугаас оддын алдар суу ялгардгийн адил бага алдар суу болох “телестиелчүүдийн алдар сууг бид харав.

82 Эдгээр нь Христийн сайн мэдээг ч, Есүсийн тухай “гэрчлэлийг ч хүлээн аваагүй тэд юм.

83 Эдгээр нь Ариун Сүнсийг үгүйсгэдэггүй тэд юм.

84 Эдгээр нь “тамд доош хаягдсан тэд юм.

85 Эдгээр нь “сүүлчийн амилуулалт хүртэл, Их Эзэн, бүр Христ ^бХурга ажлаа дуусгах хүртэл ^бчөтгөрөөс гэтэлгэгдэх нь үгүй тэд юм.

86 Эдгээр нь террестриелчүүдийн тохинууллаар дамжуулан Ариун Сүнсийг хүлээн авдаг боловч мөнхийн дэлхийд түүний бүрэн

71б 1 Кор. 15:40–41.

72а С ба Г 137:7, 9.

су Хууль.

73а С ба Г 88:99; 138:8.

су Там; Нас

барагсдын аврал.

б Алма 40:11–14.

су Сүнс.

в су Сайн мэдээ.

г 1 Петр 3:19–20; 4:6;

С ба Г 138:28–37.

74а су Гэрчлэл.

78а 1 Кор. 15:40–42.

79а С ба Г 56:16.

81а С ба Г 88:31.

су Телестиел

алдар суу.

82а С ба Г 138:21.

84а 2 Ниф. 9:12;

Алма 12:11.

су Там.

85а Алма 11:41;

С ба Г 43:18;

88:100–101.

б су Бурханы Хурга.

в су Чөтгөр.

байдлыг хүлээн авдаггүй тэд юм;

87 Мөн терристриелчүүд нь селестиелчүүдийн “тохинуул-лаар дамжуулан буюу.

88 Мөн тэрчлэн телестиел-чүүд үүнийг тэдний төлөө тохинуулахаар томилогддог, эсвээс тэдний төлөө тохи-нуулагч сүнснүүд байхаар томилогддог тэнгэр элчүү-дийн тохинууллаас хүлээн авдаг болой; учир нь тэд авралыг өвлөгчид байх болно.

89 Мөн бүх ойлголтоос давж гарсан телестиелчүүдийн ал-дар сууг тэнгэрлэг үзэгдэлд бид ийн харав;

90 Мөн Бурхан үүнийг түүнд илчлэхээс бусдаар ямар ч хүмүүн үүнийг мэдэх нь үгүй.

91 Мөн бүр алдар суунд, сүр хүчинд, хүч чадалд, мөн эзэгнэлд телестиелчүүдийн алдар сууг бүх зүйлд давам-гайлах терристриелчүүдийн алдар сууг тийн бид үзэв.

92 Мөн тийн бүх зүйлд давамгайлдаг, Бурхан, бүр Эцэг сэнтийдээ үүрд мөн мөнхөд хаанчлан суудаг селестиелчүүдийн алдар сууг бид үзэв;

93 Түүний сэнтийн өмнө бүх зүйл даруухан “хүндэтгэлд мэхийж, мөн түүнд алдар сууг үүрд мөн мөнхөд өргө-дөг бөлгөө.

94 Түүний “дэргэд оршин суудаг тэд бол “Ууган Хүү-гийн сүм болой; мөн түүний

бүрэн байдлыг мөн түүний “ач ивээлийг хүлээн авч тэд Бурханд үзэгддэгийн адилаар тэд үздэг ажгуу, мөн тэд Бур-ханд мэдэгддэгийн адилаар ‘мэддэг ажээ;

95 Мөн тэрээр тэднийг сүр хүчинд, мөн хүч чадалд, мөн эзэгнэлд “адил тэгш болгодог бөлгөө.

96 Мөн селестиелчүүдийн алдар суу нь, бүр “нарны алдар суу нэгийн адил нэг бөлгөө.

97 Мөн терристриелчүүдийн алдар суу нь, бүр сарны алдар суу нэгийн адил нэг бөлгөө.

98 Мөн телестиелчүүдийн алдар суу нь, бүр оддын алдар суу нэгийн адил нэг бөлгөө; учир нь нэг од нөгөө одноос алдар сууд ялгар-дагчлан, бүр тийн телестиел дэлхийд нэг нь нөгөөгөөсөө алдар сууд ялгардаг бөлгөө;

99 Учир нь эдгээр нь “Пау-лынх, мөн Аполлынх, мөн Кефийнх болох тэд бөлгөө.

100 Эдгээр нь зарим нь нэгнийх мөн зарим нь нөгөө-гийнх нь — зарим нь Хрис-тийнх мөн зарим нь Иоханых, мөн зарим нь Мосегийнх, мөн зарим нь Елиасынх, мөн зарим нь Есаиасынх, мөн зарим нь Исаиагийнх, мөн зарим нь Енохынх хэмээн хэлдэг тэд юм;

101 Гэвч сайн мэдээг, мөн Есүсийн тухай гэрчлэлийг ч, мөн бошиглогчдыг ч, мөн

87a С ба Г 138:37.

93a су Хүндэтгэл.

94a С ба Г 130:7.

б су Анх төрсөн.

в су Ач ивээл.

г 1 Кор. 13:12.

95a С ба Г 29:13; 78:5–7;

84:38; 88:107; 132:20.

96a 1 Кор. 15:40–41.

99a 1 Кор. 3:4–7, 22.

“үүрдийн гэрээг ч хүлээж аваагүй болгөө.

102 Эцсийн эцэст, эдгээр нь Ууган Хүүгийн “сүмд ^баваачигдахын тулд, мөн үүлэнд хүлээн авагдахын тулд гэгээнтнүүдтэй хамт цуглуулагдах нь үгүй болой.

103 “Эдгээр нь ^бхудал хэлэгчид, мэрэг төлөгчид, мөн ^бсадарлагчид, мөн завхайрагчид, мөн худал хуурмагт дурладаг мөн тийн үйлддэг тэд юм.

104 Эдгээр нь дэлхий дээр Бурханы “хилэгнэлд зовдог тэд юм.

105 Эдгээр нь мөнхийн галын “өс хонзонд зовох тэд юм.

106 Эдгээр нь “тамд доош хаягдаж мөн Христ бүх дайсныг хөл дороо ^бзахирч мөн өөрийн ажлыг “төгөлдөржүүлэх цаг хугацааны “бүрэн байдлыг хүртэл, ^бБүхнийг чадагч Бурханы хилэгнэлд “зовдог тэд юм;

107 Тэрээр хаант улсыг өгч мөн үүнийг Эцэгт толбогүй толилуулан: “Дарсны шахуургыг, бүр Бүхнийг Чадагч Бурханы догшин хилэгнэлийн дарсны шахуургыг би ганцаараа дийлж мөн ^бгиш-

гэлээ хэмээн өгүүлэх тэр үед буюу.

108 Тэгээд тэрээр, сүр хүчнийхээ “сэнтийд үүрд мөн мөнхөд хаанчлан суухаар алдар суугийнхаа титмээр титэмлэгдэх болно.

109 Гэвч болгоогтун, мөн харагтун, телестиел дэлхийн алдар суу хийгээд оршин суугчид нь далайн эрэг дээрх элс мэт, эсвээс тэнгэрийн огторгуй дахь одод мэт тоо томшгүй олон болохыг бид үзэв;

110 Мөн: Эдгээр бүгд сэнтий дээрээ үүрд мөн мөнхөд залардаг түүнд өвдөг сөгдөх болно, мөн хэл болгон “хүлээн зөвшөөрөх болно хэмээн өгүүлэх Их Эзэний дуу хоолойг сонсов;

111 Учир нь тэд ажлуудынхаа дагуу шүүгдэх болно, мөн хүн болгон бэлтгэгдсэн “харшуудад өөрийн ^бажлуудын дагуу, өөрийн эзэгнэлийг хүлээн авах болно;

112 Мөн тэд Бүхний Дээдийн үйлчлэгчид байх болно; гэвч Бурхан хийгээд Христийн “оршдог ^бтэнд, төгсгөлгүй дэлхийнүүдийн цаг хугацаанд тэд очиж чадах нь үгүй.

113 Энэ бол бидний үзсэн,

101a су Шинэ бөгөөд үүрдийн гэрээ.
102a С ба Г 78:21.
б 1 Тес. 4:16–17;
С ба Г 88:96–98.
103a Илч. 21:8;
С ба Г 63:17–18.
б су Худал хэлэх.
в су Завхайрал.
104a су Ял.
105a Иудей 1:7.

106a су Там.
б 1 Кор. 15:24–28.
в Евр. 10:14.
г Ефес 1:10.
д С ба Г 87:6.
е С ба Г 19:3–20.
107a Эхл. 49:10–12;
Иса. 63:1–3.
б Илч. 19:15;
С ба Г 88:106;
133:46–53.

108a С ба Г 137:3.
110a Филип. 2:9–11;
Мозая 27:31.
111a Иохан 14:2;
С ба Г 59:2; 81:6.
б Илч. 20:12–13.
су Ажлууд.
112a Илч. 21:23–27.
б С ба Г 29:29.

биднийг Сүнсэнд байх зуур бичихийг бидэнд зарлигласан тэрхүү үзэгдлийн төгсгөл болой.

114 Гэвч Их Эзэний ажлууд, мөн алдар суун дахь мөн хүч чадал хийгээд эзэгнэл дэх бүх ойлголтоос давж гарсан, бидэнд түүний үзүүлсэн хаант улсын “нууцууд” агуу хийгээд гайхамшигтай билээ.

115 Үүнийг Сүнсэнд байх үедээ бичих ёсгүйг тэрээр бидэнд зарлигласан болой, мөн хүмүүнд хэлэх нь “хууль бус бөлгөө”;

116 Мөн тэдгээрийг хүмүүнд мэдүүлэх “боломжгүй бөлгөө, учир нь тэдгээр нь өөрийг нь хайрладаг, мөн түүний өмнө

өөрсдийгөө цэвэршүүлдэг тэдэнд Бурхан өгдөг гагцхүү Ариун Сүнсний хүчээр үзэгдэх мөн “ойлгогдох боломжтой бөлгөө”;

117 Өөрсдөө үзэх хийгээд мэдэх энэхүү онцгой боломжийг тэрбээр тэдэнд соёрхдог болой;

118 Учир нь Сүнсний хүчээр хийгээд тохинууллаар дамжуулан, тэд махан бодид байхдаа алдар суугийн дэлхий дэх түүний оршихуйг тэвчиж чадах болой.

119 Мөн алдар суу, мөн алдар хүндэтгэл, мөн эзэгнэл Бурханд хийгээд Хурганд үүрд мөн мөнхөд байх болтугай. Амен.

ХЭСЭГ 77

1832 оны гуравдугаар сард Огайогийн Хайрамд Бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оршивой (History of the Church, 1:253–255). “Судруудыг орчуулахтай холбогдуулан, Гэгээнтэн Иоханы Илчлэлтийн дараах тайлбарыг би хүлээн авсан билээ” хэмээн Бошиглогч бичжээ (History of the Church, 1:253).

1–4, Амьтад сунстэй бөгөөд мөнхийн дэлхий дээр мөнхийн аз жаргалд орших болно; 5–7, Энэ дэлхий 7,000 жилийн хугацаанд оршин тогтнох бөлгөө; 8–10, Олон өөр тэнгэр элчүүд сайн мэдээг сэргээж мөн дэлхий дээр тохинуулдаг; 11, 144,000-ын тамгалалт; 12–14, Христ долоон мянга дахь жилийн эхэнд ирэх болно; 15, Иудей

үндэстний тул хоёр бошиглогч бэлтгэгдэх болно.

АСУУЛТ. Илчлэлтийн 4-р бүлэг, 6-дугаар шүлэгт Иоханы өгүүлсэн шилэн “тэнгис юу вэ?”

Хариулт. Энэ бол өөрийнхөө ариусгагдсан, үхэшгүй, мөн “мөнхийн байдал дахь” дэлхий бөлгөө.

114a Иаков 4:8.
б Илч. 15:3;
Морм. 9:16–18;
Моисе 1:3–5.
115a 2 Кор. 12:4.

116a 3 Ниф. 17:15–17;
19:32–34.
б 1 Кор. 2:10–12.
77 1a С ба Г 130:6–9.
б су Дэлхий—

Дэлхийн эцсийн байдал; Селестиел алдар суу.
в С ба Г 88:17–20,
25–26.

2 А. Мөн энэ шүлэгт өгүүлэгдсэн дөрвөн амьтнаар бид юуг ойлгох ёстой вэ?

Х. Тэдгээр нь “тэнгэр, Бурханы ⁶диваажин, хүмүүний мөн амьтдын, мөн мөлхөгч зүйлүүдийн, мөн огторгуй дахь жигүүртнүүдийн ^ааз жаргалыг дүрслэхэд Илчлэгч Иоханы хэрэглэсэн ^взүйрлэсэн утгатай хэллэгүүд болой; тэр нь зуурдын зүйлийн адил төстэй байдал дахь сүнсэн биет бөлгөө; мөн тэр нь сүнслэг зүйлийн адил төстэй байдал дахь зуурдын зүйл бөлгөө; өөрийнх нь биеийн адил төстэй байдал дахь хүмүүний ^ссүнс болой, тэрчлэн бас ^дамьтны сүнс, мөн Бурханы бүтээсэн бусад амьд болгоных бөлгөө.

3 А. Мөнөөх дөрвөн амьтан тус тусдаа дөрвөн амьтнаар хязгаарлагдах уу, эсвэл тэд ангиуд эсвээс зүйлүүдийг төлөөлдөг үү?

Х. Тэдгээр нь тогтоосон журам буюу бүтээлтийн “хүрээн дэх өөрсдийнхөө мөнхийн ^баз жаргалд баясдаг зүйлүүдийн алдар сууг төлөөлөх Иоханд үзүүлэгдсэн дөрвөн амьтнаар хязгаарлагддаг тус тусдаа амьтад болой.

4 А. Амьтдад байсан нүднүүд хийгээд далавчуудаар бид юуг ойлгох ёстой вэ?

Х. Тэдгээрийн нүднүүд

гэрэл ба “мэдлэгийг, мөнхүү тэдгээр нь мэдлэгээр дүүрэн байгааг төлөөлж буй; мөн тэдгээрийн далавчнууд нь хөдлөхийн тулд, үйлдэхийн тулд гэхчлэн ^гхүчийг төлөөлж буй.

5 А. Иоханаар өгүүлэгдсэн хорин дөрвөн “ахлагчаар бид юуг ойлгох ёстой вэ?

Х. Иоханы харсан эдгээр ахлагчид бол тохинууллын ажилд ^дитгэлтэй байсан бөгөөд нас нөгчсөн ахлагчид хэмээн бид ойлгох ёстой; ^е“долоон сүмд харьяалагддаг байсан бөгөөд дараа нь Бурханы диваажинд байсан тэд болой.

6 А. Иоханы харсан ар тал дээрээ долоон тамгаар “тамгалагдсан байсан тэр номоор бид юуг ойлгох ёстой вэ?

Х. Энэ нь Бурханы илчлэгдсэн таалал, ^жнууцууд, мөн ажлуудыг; энэ ^з“дэлхийг насралтынх нь буюу цаг зуурын оршин тогтнолынх нь долоон мянган жилийн турш үр ашигтайгаар зохицуулах түүний нууцлаг зүйлүүдийг агуулдаг хэмээн бид ойлгох ёстой.

7 А. Энэ нь үүгээр лацдагдсан тэрхүү долоон тамгаар бид юуг ойлгох ёстой вэ?

Х. Эхний тамга нь “эхний мянган жилийн зүйлүүдийг, хоёр дахь нь тэрчлэн хоёр

2а су Тэнгэр.
б су Диваажин.
в су Баяр баясгалан.
г су Билэг тэмдгийн.
д Ифер 3:15-16;
Абр. 5:7-8.
су Сүнс.

е Мосе 3:19.
3а С ба Г 93:30;
Мосе 3:9.
б С ба Г 93:33-34.
4а су Мэдлэг.
б су Хүч.
5а Илч. 4:4, 10.

б Илч. 14:4-5.
в Илч. 1:4.
6а Илч. 5:1.
б су Бурханы
нууцууд.
в су Газар дэлхий.
7а С ба Г 88:108-110.

дахь мянган жилийнхийг, мөн энэчлэн долоо дахийг хүртэл агуулж буй хэмээн бид ойлгох ёстой.

8 А. Илчлэлтийн 7-р бүлэг мөн 1-р шүлэгт өгүүлэгдсэн дөрвөн тэнгэр элчээр бид юуг ойлгох ёстой вэ?

Х. Тэд бол Бурханаас урагш илгээгдсэн, амьдралыг хамгаалах болон устгахын тулд газар дэлхийн дөрвөн зүг дээр хүч өгөгдсөн дөрвөн тэнгэр элч хэмээн бид ойлгох ёстой; эдгээр нь тэнгэрүүдийг хаах, амьдралд лацдах, эсвээс харанхуйн “газруудад доош хаях хүчтэй байж, ⁶үүрдийн сайн мэдээг бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүст итгэмжлэх тэд болой.

9 А. Илчлэлтийн 7-р бүлэг мөн 2-р шүлэгт дорнодоос буун ирж буй тэнгэр элчээр бид юуг ойлгох ёстой вэ?

Х. Дорнодоос буун ирж буй тэнгэр элч нь “Израилын арван хоёр овгийн дээрх амьд Бурханы тамга өгөгдсөн тэрбээр юм хэмээн бид ойлгох ёстой; иймийн тул, тэрбээр үүрдийн сайн мэдээ бүхий дөрвөн тэнгэр элчид: Бидний Бурханы үйлчлэгчдийн ⁶духанд нь бид тамга дарсан байх хүртэл дэлхийг, мөн тэнгис далайг ч, мөн модыг ч бүү гэмтээ. Мөн, хэрэв та нар

үүнийг хүлээн авах аваас, энэ нь Израилын овгуудыг хамтад нь цуглуулж мөн бүх зүйлийг ⁶сэргээхээр ирэх байсан ‘Елиа болой хэмээн тунхагласныг буюу.

10 А. Энэ бүлэгт өгүүлэгдсэн зүйлүүдийн гүйцэлдэх ёстой цаг нь хэзээ вэ?

Х. Тэдгээр нь “зургаа дахь мянган жилд буюу зургаа дахь тамганы нээлтэд гүйцэлдэх ёстой.

11 А. Израилын бүх овгуудаас овог бүрээс арван хоёр мянга байх нэг “зуун дөчин дөрвөн мянгын тамгалалтаар бид юуг ойлгох ёстой вэ?

Х. Тамгалагдсан тэд нь үүрдийн сайн мэдээг гүйцэтгэхийн тулд Бурханы ариун жаягт томилогдсон ⁶дээд санваартнууд хэмээн бид ойлгох ёстой; учир нь тэд бол “Ууган Хүүгийн сүмд ирэх болгоныг авчрахаар газар дэлхийн үндэстнүүдийн дээрх хүч өгөгдсөн тэнгэр элчүүдээр бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүсээс томилогдсон тэд билээ.

12 А. Илчлэлтийн 8-р бүлэгт дурдагдсан “бүрээнүүдийн дуугаар бид юуг ойлгох ёстой вэ?

Х. Бурхан зургаан өдөрт дэлхийг хийж, мөн долоо дахь өдөр нь тэрээр ажлаа дуусгаж, мөн үүнийг ⁶ариусгаж,

8а Мат. 8:11–12;
22:1–14;
С ба Г 133:71–73.
б Илч. 14:6–7.
9а Илч. 7:4–8.
б Езек. 9:4.
в су Сайн мэдээний

сэргээлт.
г су Елиа.
10а Илч. 6:12–17.
11а Илч. 14:3–5.
б су Дээд санваартан.
в С ба Г 76:51–70.

су Анх төрсөн.
12а Илч. 8:2.
б Эхл. 2:1–3;
Ег. 20:11; 31:12–17;
Мозая 13:16–19;
Мосе 3:1–3;
Абр. 5:1–3.

мөн тэрчлэн газрын “тоосноос хүнийг бий болгосон юм, бүр үүнчлэн долоо дахь мянган жилийн эхэнд Их Эзэн Бурхан дэлхийг ‘ариусгаж, мөн хүмүүний авралыг дүүргэн, мөн бүх зүйлийг ^ашүүх болно, мөн тэрээр бүх зүйлийг бүх зүйлийн төгсгөл хүртэл лацадсан байх тэрхүү үедээ тэрээр өөрийн хүчинд эс тавьснаас бусад бүх зүйлийг ‘гэтэлгэх болно хэмээн бид ойлгох ёстой; мөн долоон тэнгэр элчийн бүрээн дуу нь долоо дахь мянган жилийн эхлэлд түүний ажлын бэлтгэл хийгээд төгсгөл — түүний ирэлтийн цагийн өмнөх замын бэлтгэл болой.

13 А. Илчлэлтийн 9-р бүлэгт бичигдсэн зүйлүүд хэзээ гүйцэлдэх ёстой вэ?

Х. Тэдгээр нь Христийн ирэлтийн өмнө долоо дахь

лац нээгдсэний дараа гүйцэлдэх ёстой.

14 А. Илчлэлтийн 10-р бүлэгт дурдагдсан, Иоханы “идсэн бяцхан номоор бид юуг ойлгох ёстой вэ?

Х. Энэ бол Израилын овгуудыг ^бцуглуулах түүний үүрэг даалгавар, мөн ёслол байсан гэдгийг бид ойлгох ёстой; болгоогтун, энэ нь бичигдсэн члэн, ирж мөн бүх зүйлийг ^ссэргээх ёстой Елиа бөлгөө.

15 А. Илчлэлтийн арваннэгдүгээр бүлэг дэх хоёр “гэрчээр юу ойлгогдох ёстой вэ?

Х. Тэд бол ^ээцсийн өдрүүдэд, ^ссэргээлтийн цагт, тэднийг цугларч, мөн өвөг дээдсийнхээ ‘нутагт Иерусалимын хотыг байгуулсны дараа иудейчүүдэд бошиглохын тулд ^иИудей үндэстний тулд бэлтгэгдэх хоёр бошиглогч болой.

ХЭСЭГ 78

1832 оны гуравдугаар сард Огайогийн Хайрамд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:255–257). Ядууст зориулсан агуулах байгуулах зорилгоор Их Эзэнээс Иосеф Смитэд журам өгөгдсөн болой. Илчлэлтэд Их Эзэний дурдсан хувь хүмүүс хэн болох нь дэлхийгээр мэдэгдэх нь ямагт хүсүүштэй биш байв, үүнээс үүдэн энэ болон дараах зарим илчлэлтийг хэвлэхэд ах нар өөрсдийнх нь нэрнээс өөрөөр дурдагдсан байлаа. Хувь хүмүүсийн нэрсийг мэдэгдэхгүй байлгах зайлшгүй шаардлага үгүй болоход тэдний нэрсийг хаалтанд бичдэг байв. Нууцалсан нэрийг үргэлжлүүлэх зайлшгүй шаардлага өнөөдөр байхгүй

12в Эхл. 2:7.
 г С ба Г 88:17–20.
 д су Есүс Христ—
 Шүүгч.
 е су Гэтэлгэх,
 Гэтэлгэгдэх,
 Гэтэлгэл.

14а Езек. 2:9–10; 3:1–4;
 Илч. 10:10.
 б су Израил—
 Израилын
 цугларалт.
 в Мат. 17:11.
 15а Илч. 11:1–14.

б су Эцсийн өдрүүд,
 Хожмын өдрүүд,
 в су Сайн мэдээний
 сэргээлт.
 г Амос 9:14–15.
 д су Иудейчүүд.

учир, жинхэнэ нэрнүүдийг гар бичмэлийн эхүүдэд байгаагаар нь эдүгээ хэрэглэсэн бөлгөө.

1-4, Гэгээнтнүүд агуулах зохион байгуулж мөн үүсгэн бий болгох ёстой; 5-12, Өөрсдийн эд хөрөнгийг ухаалгаар хэрэглэх нь авралд хөтөлдөг; 13-14, Сүм нь дэлхийн хүчнүүдээс тусгаар байх ёстой; 15-16, Михаил (Адам) Ариун Нээний (Христ) удирдлага дор үйлчилдэг; 17-22, Итгэлтнүүд адислагдсан болой, учир нь тэд бүх зүйлийг өвлөх болно.

ИХ ЭЗЭН Бага Иосеф Смитэд ярьж, өгүүлсэн нь: Намайг анхаарагтун, миний сүмийн “дээд санваарт томилогдсон тэд, өөрсдийгөө хамтад нь цуглуулсан тэд хэмээн чиний Бурхан Их Эзэн хэлж байна;

2 Мөн миний өмнө чиний толилуулсан тэр зүйлд аврал чамд байж болохын тулд чамайг дээрээс “томилсон, мэргэн ухааны үгийг чихэнд чинь ярих миний ^бзөвлөгөөг анхаарагтун хэмээн Их Эзэн бибээр хэлж байна.

3 Учир нь үнэнээр би чамд хэлж байна, цаг нь иржээ, мөн эдүгээ ойрхон байна; мөн болгоогтун, мөн харагтун, энэ газар хийгээд мөн “Сионы нутагт аль алинд нь миний хүмүүсийн ^бядууст зориулсан “агуулахын ажил хэргүүдийг

зохицуулан мөн үндэслэн байгуулахад миний хүмүүсийн ^ббайгууллага байх ёстой нь шаардлагатай болжээ —

4 Учир нь та нарын өөрсдийгөө даатгасан миний сүмийн байнгын бөгөөд үүрдийн зохион байгуулалт мөн тогтсон журам нь хүмүүний аврал мөн тэнгэрт байгаа та нарын Эцэгийн алдар суугийн тулд урагшлах зарчим болой;

5 Та нар тэнгэрлэг зүйлүүдэд “адил тэгш байж болох буюу, тийм ээ, тэнгэрлэг зүйлүүдийг олж авахын тулд, тэрчлэн дэлхийн зүйлүүдэд ч мөн адил буюу.

6 Хэрэв та нар дэлхийн зүйлүүдэд тэгш бус байх аваас та нар тэнгэрлэг зүйлүүдийг олж авахад тэгш байж чадахгүй.

7 Учир нь хэрэв “селестиел дэлхийд та нарт газар өгөхийг та нар надаас хүсэх аваас, та нарт миний зарлигласан мөн та нараас шаардсан тэрхүү зүйлүүдийг ^бхийснээр та нар өөрсдийгөө “бэлтгэх ёстой.

8 Мөн эдүгээ, үнэнээр ийн Их Эзэн хэлдэг, бүх зүйл миний “алдар сууд, энэ ^бнэгдсэн жаягт нэгдсэн та нараар хийгдэх ёстой нь зүйтэй байна;

78 1a су Мелкизедек санваар.

2a су Томилох, Томилолт.

б су Зөвлөгөө.

3a С ба Г 57:1-2.

б С ба Г 42:30-31.

су Халамж.

в С ба Г 72:9-10;

83:5-6.

г С ба Г 82:11-12,

15-21.

5a С ба Г 49:20.

су Өргөл болгох,

Өргөлийн хууль.

7a су Селестиел

алдар суу.

б С ба Г 82:10.

в С ба Г 29:8; 132:3.

8a Моце 1:39.

б С ба Г 92:1.

9 Эсвээс, өөрөөр хэлбэл, миний үйлчлэгч Ньюел К.Витней мөн миний үйлчлэгч Бага Иосеф Смит мөн миний үйлчлэгч Сидней Ригдон Сионд байгаа гэгээнтнүүдтэй зөвлөлд сууг;

10 Эс тэгвээс тэд харалган болж мөн өөрсдөд нь бэлтгэгдсэн тэр зүйлүүдийг ойлгохгүй байхын тулд “Сатан тэдний зүрх сэтгэлийг үнэнээс холдуулахыг эрэлхийлдэг.

11 Иймийн тул, үүрэг буюу зөрчигдөж үл болох үүрдийн “гэрээгээр өөрсдийгөө бэлтгэх мөн зохион байгуулах зарлигийг би та нарт өгч байна.

12 Мөн үүнийг зөрчдөг тэрээр өөрийн албан тушаал хийгээд сүмд байхаа алдах болно, мөн гэтэлгэлийн өдөр хүртэл Сатаны “тамлалд хүргэгдэх болно.

13 Болгоогтун, энэ бол та нарыг бэлтгэх миний тэрхүү бэлтгэл, мөн тэрхүү суурь мөн та нарт миний өгөх үлгэр жишээ бөлгөө, үүгээр та нар өөрсдөдөө өгөгдсөн зарлигуудыг гүйцэлдүүлж болох бөлгөө;

14 Миний санаа тавилтаар дамжин, чам дээр “гай зовлон ирэх хэдий ч, сүм селестиел дэлхийн доорх бусад бүх бие-

түүдийн дээр тусгаар байдалтай байж болохын тулд буюу;

15 Та нар өөрсөд тань бэлтгэгдсэн “титэмд хүрч болохын тулд, мөн олон хаант улсын дээр “захирагчид болгогдож болохын тулд хэмээн Их Эзэн Бурхан, “Адам-ондай-Аманы сууриудыг үндэслэн байгуулсан Сионы Ариун Нэгэн бибээр хэлж байна;

16 Та нарын хаанхүү “Михайлыг томилсон, мөн түүний хөлийг тогтоосон, мөн түүнийг дээр төлөвшүүлсэн, өдрүүдийн эхлэл буюу амьдралын төгсгөлгүй болох Ариун Нэгэний зөвлөгөө хийгээд чиглүүлэл дор авралын түлхүүрүүдийг түүнд өгсөн бибээр буюу.

17 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, та нар бяцхан хүүхдүүд бөлгөө, мөн хичнээн агуу адислалуудыг Эцэг гартаа байлгаж мөн та нарын төлөө бэлтгэснийг та нар хараахан ойлгоогүй байгаа билээ;

18 Мөн эдүгээ та нар бүх зүйлийг “дааж чадах нь үгүй; гэсэн хэдий ч, зоригтой бай, учир нь би та нарыг “удирдах болно. Хаант улс та нарынх болой, мөн үүн дээрх адислалууд та нарынх билээ, мөн “үүрд мөнхийн баялагууд та нарынх бөлгөө.

10a су Чөтгөр.

11a су Гэрээ.

12a 1 Кор. 5:5;

С ба Г 82:21;

104:8–10.

14a С ба Г 58:2–4.

15a су Титэм;

Өргөмжлөл.

б Илч. 5:10;

С ба Г 76:56–60;

132:19.

в су Адам-ондай-

Аман.

16a С ба Г 27:11;

107:54–55.

су Адам.

18a Иохан 16:12;

3 Ниф. 17:2–3;

С ба Г 50:40.

б С ба Г 112:10.

в су Мөнх амьдрал.

19 Мөн бүх зүйлийг “талархалтайгаар хүлээн авдаг тэрээр алдар суут болгогдох болно; мөн энэ дэлхийн зүйлүүд, тийм ээ, бүр ^бзуу дахин, түүнд нэмэгдэх болно.

20 Иймийн тул, чамд миний зарлигласан тэр зүйлүүдийг хийгтүн хэмээн чиний Гэтэлгэгч, бүр чамайг “авахаас өмнө бүх зүйлийг бэлтгэдэг

^бАманы Хүү бибээр хэлж байна;

21 Учир нь та нар Ууган Хүүгийн “сүм болой, мөн тэрээр та нарыг үүлэн дунд ^бавч мөн хүн болгонд хувийг нь хүртээх болно.

22 Мөн итгэлтэй бөгөөд “мэргэн ^бдаамал болох тэрээр ^ббүх зүйлийг өвлөх болно. Амен.

ХЭСЭГ 79

1832 оны гуравдугаар сард Огайогийн Хайрамд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршивой (History of the Church, 1:257).

1–4, Жаред Картер сайн мэдээг Тайтгаруулагчаар номлохоор дуудагдав.

МИНИЙ үйлчлэгч Жаред Картер өөрийн томилогдсон “томилолтын тэрхүү хүчинд, агуу баяр хөөрийн баярт мэдээг, бүр үүрдийн сайн мэдээг тунхаглан дорнод мужууд уруу, газраас газарт мөн хотоос хотод дахин явах ёстой нь миний таалал бөлгөө гэдгийг үнэнээр би чамд хэлж байна.

2 Мөн үнэнийг хийгээд хаашаа явах замыг нь түүнд заах “Тайтгаруулагчийг бибээр түүнд илгээх болно;

3 Мөн тэрээр итгэлтэй байхын хэрээр, би түүнд тариан боодлуудаар дахин титэм хүртээх болно.

4 Иймийн тул, миний үйлчлэгч Жаред Картер зүрх сэтгэл чинь баяртай байг, мөн бүү “эмээ хэмээн чиний Их Эзэн, бүр Есүс Христ бибээр хэлж байна. Амен.

ХЭСЭГ 80

1832 оны гуравдугаар сард Огайогийн Хайрамд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршивой (History of the Church, 1:257).

19a Мозая 2:20–21.
су Талархалтай,
Талархах, Талархал
өргөх.
^б Мат. 19:29.
20a 1 Тес. 4:17.
^б С ба Г 95:17.

21a С ба Г 76:53–54.
^б С ба Г 88:96–98.
22a С ба Г 72:3–4.
^б су Даамал, Ажил
үүрэг.
^в С ба Г 84:38.
79 1a С ба Г 52:38.

су Томилох,
Томилолт.
2a Иохан 14:26.
су Тайтгаруулагч.
4a С ба Г 68:5–6.

1–5, *Стефен Бурнетт мөн Эден Смит нар өөрсдийн сонгосон газарт номлохоор дуудагдав.*

ҮНЭНЭЭР, Их Эзэн өөрийн үйлчлэгч Стефен Бурнетэд ийн хэлж байна: Явагтун чи, чи дэлхий уруу явж мөн чиний дуу хоолойн дуун дор явдаг хүмүүн бүрт сайн мэдээг “номлогтун.

2 Мөн чи хамтрагчийг хүсдэг учраас, бибээр өөрийн үйлчлэгч Эден Смитийг чамд өгөх болно.

3 Иймийн тул, умард эсвэл өмнөд эсвэл дорнод эсвэл өрнөдөд ч байна уу, энэ нь хамаагүй, та нар явж мөн миний сайн мэдээг номлогтун, учир нь та нар буруудах нь үгүй.

4 Тиймийн тул, та нар сонсон, мөн үнэнээр итгэдэг, мөн үнэн гэдгийг нь “мэддэг зүйлүүдээ тунхаглагтун.

5 Болгоогтун, энэ бол та нарыг “дуудсан, та нарын Гэтэлгэгч, бүр Есүс Христийн таалал бөлгөө. Амен.

ХЭСЭГ 81

1832 оны гуравдугаар сард *Огайогийн Хайрамд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой* (History of the Church, 1:257–258). *Фредерик Г. Виллямс* дээд санваартан мөн Дээд Санваартны Ерөнхийлөгчийн Зөвлөлд зөвлөх байхаар дуудагдав. 1832 оны гуравдугаар сард энэхүү илчлэлт хүлээн авагдах үед энэ нь *Жесси Гаусыг Ерөнхийлөгчийн Зөвлөлд Иосеф Смитийн зөвлөхийн албан тушаалд дуудсаныг түүхэн цэдгүүд харуулдаг. Гэсэн хэдий ч, тэрээр энэхүү томилолтод нийцэх байдлыг үргэлжлүүлэхэд бүтэлгүйтэж, үүний улмаас уг дуудлага дараа нь Фредерик Г.Виллямст шилжжээ. Уг илчлэлт (1832 оны гуравдугаар сарын нэгэн өдөр) тус зохион байгуулалтад, ялангуяа зөвлөхийн албан тушаалд дуудах, мөн уг томилолтын ёс жаягийг тайлбарласан учир Тэргүүн зөвлөлийн албан ёсны зохион байгуулалт өөд хийсэн алхам хэмээн тооцогдох ёстой. Гаус Ах хэсэг хугацаанд үйлчилж байсан боловч 1832 оны арванхоёрдугаар сард Сүмээс хөөгдсөн ажээ. 1832 оны гуравдугаар сарын 18-нд Виллямс Ах дурдсан албан тушаалд томилогджээ.*

1–2, *Хаант улсын түлхүүрүүд ямагт Тэргүүн Зөвлөлөөр атгагддаг; 3–7, Хэрэв Фредерик Г.Виллямс өөрийн тохинуулалд итгэлтэй байх аваас, тэрээр мөнх амьдралтай байх болно.*

ҮНЭНЭЭР, үнэнээр би өөрийн үйлчлэгч Фредерик Г.Виллямс чамд хэлж байна: Ярьж буй түүний дуу хоолойг, өөрийн Бурхан Их Эзэний үгийг дуулагтун, мөн

өөрийн дуудагдсан, бүр миний сүмд “дээд санваартан, мөн миний үйлчлэгч Бага Иосеф Смитэд зөвлөх байх тэрхүү дуудлагад анхаарал тавигтун;

2 Дээд санваарын “Ерөнхийлөгчийн Зөвлөлд ямагт харьяалагддаг хаант улсын ^бтүлхүүрүүдийг бибээр түүнд өгсөн билээ:

3 Иймийн тул, үнэнээр би түүнийг хүлээн зөвшөөрч мөн түүнийг, тэрчлэн миний томилсон албан тушаалд чи зөвлөхөд, чангаар болон зүрх сэтгэлдээ, олны өмнө болон ганцаар хийх залбиралд, тэрчлэн амьдарч байгаа нутагтаа, мөн ахан дүүсийнхээ дунд сайн мэдээг тунхаглах тохинуулалдаа ямагт итгэлтэй байхын хэрээр чамайг адислах болно.

4 Мөн эдгээр зүйлүүдийг хийхэд чи нөхөддөө хамгийн агуу сайныг үйлдэх болно, мөн өөрийн Их Эзэн болох түүний “алдар сууд тус нэмэрлэх болно.

5 Иймийн тул, итгэлтэй байгтун; чамайг миний томилсон албан тушаалд үүргээ биелүүлэгтүн; сул доройчуудад “тусал, доош унжсан гарнуудыг өргөгтүн, мөн ^бсул дорой өвдөгнүүдийг “хүчирхэг болгогтун.

6 Мөн хэрэв чи эцсээ хүртэл итгэлтэй байх аваас чи “үхэшгүй байдлын титэм, мөн Эцэгийнхээ өргөөнд миний бэлтгэсэн ^бхаршуудад “мөнх амьдралтай байх болно.

7 Болгоогтун, мөн харагтун, эдгээр нь Альфа ба Омега, бүр Есүс Христийн үгс болой. Амен.

ХЭСЭГ 82

1832 оны дөрөвдүгээр сарын 26-нд Миссурийн Жаксон гүнлэгт Бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:267-269). Уг үйл явдал нь 1832 оны нэгдүгээр сарын 25-нд Огайогийн Амхерстэд дээд санваартнууд, ахлагчид мөн гишүүдийн чуулган дээр өмнө нь тэрээр томилогдсон албан тушаалд, Бошиглогч Иосеф Смит Дээд Санваартны Ерөнхийлөгчөөр дэмжин батлагдсан Сүмийн ерөнхий зөвлөлийн хурал байлаа (хэсэг 75-ын толгой гарчгийг үз). Энд нэрлэгдсэн хүмүүсийг нууцлахын тулд энэхүү илчлэлтийг нийтлэхэд өмнө нь байсан ердийн биш нэрсийг ашигласан байлаа (хэсэг 78-ын толгой гарчгийг үз).

81 1а су Дээд санваартан.
2а С ба Г 107:8-9, 22. су Тэргүүн Зөвлөл.
б су Санваарын түлхүүрүүд.

4а Мосе 1:39.
5а Мозая 4:15-16.
б Иса. 35:3.
в С ба Г 108:7.
6а су Мөнх бус, Мөнх бус байдал.

б Иохан 14:2-3;
С ба Г 59:2; 106:8.
в су Мөнх амьдрал; Өргөмжлөл.

1–4, Их нь өгөгдсөн түүнээс их нь шаардагддаг; 5–7, Харанхуй нь дэлхийд давамгайлдаг; 8–13, Бид түүний хэлснийг хийхэд Их Эзэн үүрэг хүлээдэг; 14–18, Сион үзэсгэлэнт байдал хийгээд цэвэр ариунд өсөн дэгжих ёстой; 19–24, Хүн болгон хөршийнхөө ашиг сонирхлыг эрэлхийлэх ёстой.

ҮНЭНЭЭР, үнэнээр би өөрийн үйлчлэгч та нарт хэлнэ, та нар бие биенийхээ зөрчлийг “уучлахын хэрээр, бүр түүнчлэн Их Эзэн бибээр та нарыг өршөөнө.

2 Гэсэн хэдий ч, үлэмж ихээр нүгэл үйлдсэн тэд та нарын дунд буй; тийм ээ, бүр та нар “бүгдээрээ нүгэл үйлдлээ; гэвч үнэнээр би та нарт хэлнэ, үүнээс хойш болгоомжлогтун, мөн гашуун шүүлтүүд та нарын толгой дээр буухгүйн тулд нүглээс татгалзагтун.

3 Учир нь “их нь өгөгдсөн түүнээс их нь ^бшаардагдах буюу; мөн агуу ^вгэрлийн эсрэг нүгэл үйлддэг тэрээр илүү агуу буруушаалтыг хүлээж авах болно.

4 Та нар “илчлэлтийн төлөө миний нэрийг дууддаг, мөн бибээр тэдгээрийг та нарт өгдөг; мөн та нарт миний өгсөн айлдваруудыг сахихгүй

байхын хэрээр та нар зөрчил гаргагчид болдог; мөн ^бшударга ёс хийгээд шүүлт нь миний хуулинд оноогдсон шийтгэл болой.

5 Тиймийн тул бибээр нэгд хэлдгээ би бүгдэд хэлдэг: “Сэрэмжтэй байгтун, учир нь ^бдайсан эзэгнэлүүдээ тэлдэг, мөн “харанхуй нь давамгайлдаг;

6 Мөн дэлхийн оршин суугчдын эсрэг Бурханы уур дүрэлзэж байна; мөн сайныг үйлдэх хэн ч үгүй, учир нь бүгд “замаасаа гажжээ.

7 Мөн эдүгээ, үнэнээр би та нарт хэлнэ, Их Эзэн бибээр аливаа “нүглийг та нарт тохоох нь үгүй; замаараа явж мөн дахин нүгэл бүү үйлд; гэвч нүгэл үйлддэг тэрхүү сүнсэнд ^бурьдын нүглүүд нь эргэж ирэх болно хэмээн чиний Бурхан Их Эзэн хэлдэг.

8 Мөн дахин, бибээр та нарт хэлнэ, та нар өөрсдийнхөө талаарх миний тааллыг ойлгож болохын тулд би та нарт “шинэ зарлиг өгч байна;

9 Эсвээс, өөрөөр хэлбэл, энэ нь та нарын авралын төлөө та нарт эргэж болохын тулд та нар миний өмнө хэрхэн “үйлдэж болох талаар би та нарт удирдамж өгч байна.

10 Миний хэлснийг та нар

82 1a Мат. 6:14–15;

С ба Г 64:9–11.

2a Ром 3:23.

3a Лук 12:48;

Иаков 4:17.

сү Хариуцах,

Хариуцлага,

Хариуцлагагай.

б сү Даамал, Ажил

үүрэг.

в Иохан 15:22–24.

сү Гэрэл, Христийн гэрэл.

г сү Урвалт; Нүгэл.

4a сү Илчлэлт.

б сү Шударга ёс.

5a сү Харах, Харуул.

б сү Чөтгөр.

в сү Сүнсний

харанхуй.

6a Ром 3:12;

С ба Г 1:16.

7a сү Нүгэл.

б С ба Г 1:32–33; 58:43.

8a Иохан 13:34.

9a С ба Г 43:8.

хийхэд Их Эзэн бибээр “үүрэг хүлээдэг; гэвч миний хэлснийг та нар үл хийхэд та нарт амлалт байх нь үгүй.

11 Тиймийн тул, үнэнээр би та нарт хэлнэ, миний үйлчлэгчид Эдвард Партриж мөн Ньюел К.Витней, мөн А.Сидней Гилберт мөн Сидней Ригдон, мөн миний үйлчлэгч Иосеф Смит мөн Жон Витмер мөн Оливер Каудери мөн В.В.Фелпс мөн Мартин Харрис нар зөрчлөөр зөрчигдөж үл болох үүрэг хийгээд гэрээгээр “хамтдаа холбогдох нь шаардлагатай байна, эс бөгөөс та нарын хэд хэдэн ажил үүрэгт тэр даруй шүүлт дагалдах болно—

12 Ядуусын хэрэг явдлыг хийгээд Сионы нутагт мөн Көртландын нутагт аль алинд нь бишопын зөвлөлд хамаарах бүх зүйлийг хянан зохицуулахын тулд буюу;

13 Учир нь Бүхний Дээдийн гэгээнтнүүдийн ашиг тусын тулд мөн Сионд “гадас байхын тулд би өөрийнхөө тогтоосон цагт Көртландын газар нутгийг ариулан адисалсан болой.

14 Учир нь Сион гоо үзэсгэлэнд, мөн цэвэр ариун байдалдаа өсөн дэгжих ёстой; түүний хил хязгаарууд өргө-

жин тэлэх ёстой; түүний гадаснууд бэхжих ёстой; тийм ээ, үнэнээр би та нарт хэлнэ, “Сион өндийн босч мөн “үзэсгэлэнт өмсгөлүүдээ өмсөх ёстой.

15 Тиймийн тул, энэхүү гэрээгээр та нар өөрсдийгөө холбогтун, мөн энэ нь Их Эзэний хуулиудын дагуу хийгдэх ёстой хэмээх энэхүү зарлигийг би та нарт өгч байна.

16 Болгоогтун, энэ нь тэрчлэн та нарын ашиг тусын төлөө надад орших мэргэн ухаан бөлгөө.

17 Мөн та нар “адил тэгш байх ёстой; эсвээс, өөрөөр хэлбэл, хэрэв өөрийнхөө хүслүүдэд шударга байх аваас, ажил үүргүүдийнхээ төлөө санаа тавих зүйлүүдийг хянан зохицуулах ашиг тусын тулд, хүн болгон хүслүүд хийгээд хэрэгцээнийхээ дагуу та нар өмч хөрөнгөнд адил тэгш эрхтэй байх ёстой—

18 Мөн хүн болгон “авьяас билгээ сайжруулж болохын тулд, хүн бүр өөр авьяасыг тийм ээ, бүр зуу дахин ихийг олж авч болохын тулд, нийт сүмийн хамтын өмч хөрөнгө болсон байж болохын тулд, энэ бүгд нь амьд Бурханы сүмийн ашиг тусын тулд Их

10a Иош. 23:14;
Хаад. дээд 8:23;
С ба Г 1:38;
130:20–21.
су Адислах,
Адислагдах,
Адислал;
Дуулгавартай байх,

Дуулгавартай,
Дуулгавартай
дагах.
11a С ба Г 78:3–7, 11–15.
13a Иса. 33:20; 54:2.
су Гадас.
14a су Сион.
б Иса. 52:1;

С ба Г 113:7–8.
17a С ба Г 51:3.
су Өргөл болгох,
Өргөлийн хууль.
18a Мат. 25:14–30;
С ба Г 60:13.
су Бэлэг; Сүнсний
бэлгүүд.

Эзэний “агуулахад хийгдэж болох буюу —

19 Хүн болгон хөршийнхөө анхаарал тусламжийг эрэлхийлж мөн бүх зүйлийг Бурханы алдар суугийн төлөө бүхнээ “зориулан хийх ёстой.

20 Та нар нүгэл үйлдэхгүй байхын хэрээр, энэ нь үүрдийн “нэгдсэн журам байхын тулд би та нарт, мөн та нарыг залгамжлагчдад энэхүү нэгдсэн журмыг томилсон билээ.

21 Мөн энэхүү гэрээний эсрэг нүгэл үйлддэг мөн үүний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулдаг сүнс нь миний сүмийн хуулиудын дагуу шийдэгдэх ёстой, мөн гэтэл-

гэлийн өдөр хүртэл Сатаны “тамлалд хүргэгдэх болно.

22 Мөн эдүгээ, үнэнээр би та нарт хэлнэ, шударга бус байдлын эд баялгийг ашиглан өөрсдийгөө найз нөхөдтэй болгох нь мэргэн ухаан болой, мөн тэд та нарыг устгах нь үгүй.

23 Шүүлтийг зөвхөн надад үлдээгч, учир нь энэ нь минийх бөгөөд би “хариуг нь төлөх болно. Амар амгалан та нарт байг; миний адислалууд та нарт үргэлж байг.

24 Учир нь бүр “хаант улс та нарынх болой, мөн хэрэв та нар гуйвшгүй байдлаасаа унахгүй бол үүрд байх болно. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 83

1832 оны дөрөвдүгээр сарын 30-нд Миссурийн Индепенденст Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:269–270). Бошиглогч ах нартайгаа хамт зөвлөлд хуралдаж байхад энэхүү илчлэлт хүлээн авагджээ.

1–4, Эмэгтэйчүүд хийгээд хүүхдүүд өөрсдийгөө тэтгүүлэхийн тулд өөрсдийн нөхөр хийгээд эцгүүдээс нэхэх эрхтэй; 5–6, Бэлэвсэн хийгээд өнчин хүмүүс өөрсдийгөө тэтгүүлэхийн тулд Сүмээс нэхэх эрхтэй.

ҮНЭНЭЭР, нөхрөө буюу эцгээ “алдсан сүмд харьяалагддаг эмэгтэйчүүд болон хүүхдүүдийн талаарх сүмийн

хуулиудад нэмэлт болгон, Их Эзэн ийн хэлдэг бөлгөө:

2 Эмэгтэйчүүд өөрсдийнхөө нөхрийг авагдах хүртэл өөрсдийгөө тэтгүүлэхийн тулд нөхрөөсөө “нэхэх эрхтэй; мөн хэрэв тэд зөрчил гаргагчид биш аваас, тэд сүмд нөхөрлөлтэй байх ёстой.

3 Мөн хэрэв тэд итгэлтэй биш аваас, тэд сүмд нөхөрлөлтэй байхгүй болно; гэвч

18б С ба Г 42:30–34, 55;
119:1–3.

сү Агуулах.

19а С ба Г 88:67.

сү Нүд, мэлмий.

20а сү Нэгдсэн журам.

21а С ба Г 104:8–10.

23а Ром. 12:19;

Морм. 3:15.

24а Лук 12:32;

С ба Г 64:3–5.

сү Бурханы хаант

улс буюу Тэнгэрийн хаант улс.

83 1а Иаков 1:27.

2а 1 Тим. 5:8.

тэд нутгийн хуулиудын дагуу өв хөрөнгөн дээрээ үлдэж болох буюу.

4 Бүх “хүүхэд насанд хүртлээ өөрсдийгөө тэтгүүлэхийн тулд эцэг эхээсээ нэхэх эрхтэй.

5 Мөн үүний дараа хэрэв тэдний эцэг эх тэдэнд өвийг

өгч үл чадах аваас, тэд сүмээс, эсвээс өөрөөр хэлбэл, Их Эзэний “агуулахаас нэхэх эрхтэй.

6 Мөн агуулах нь сүмийн өргөлүүдээр зохицуулагддаг байх ёстой; мөн “бэлэвсэн хийгээд өнчин хүмүүс тэрчлэн “ядуусын адилаар хангагдах ёстой. Амен.

ХЭСЭГ 84

1832 оны есдүгээр сарын 22 мөн 23-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:286–295). Есдүгээр сарын туршид, ахлагчид дорнод мужууд дахь номлолоосоо эргэн ирж, мөн хөдөлмөрүүдийнхээ талаар тайлангаа тавьж эхэлжээ. Баяр хөөрийн энэ үед тэд хэсэг зуур хамтдаа байх үед дараах захиас хүлээж авагдсан ажээ. Бошиглогч үүнийг санваарын талаарх илчлэлт хэмээн үзжээ.

1–5, Шинэ Иерусалим мөн ариун сүм Миссурид баригдах болно; 6–17, Мосегоос Адам хүртэлх санваарын дараалал өгөгдөв; 18–25, Дээд санваар Бурханы мэдлэгийн түлхүүрийг атгадаг; 26–32, Доод санваар тэнгэр элчүүдийн тохинууллын хийгээд бэлтгэл сайн мэдээний түлхүүрийг атгадаг; 33–44, Санваарын тангараг хийгээд гэрээгээр дамжуулан хүмүүн мөнх амьдралыг олдог; 45–53, Христийн Сүнс хүмүүнийг гэгээрүүлдэг, мөн дэлхий нүгэлд байдаг бөлгөө; 54–61, Гэгээнтнүүд хүлээж авсан тэдгээр зүйлүүдийнхээ талаар гэрчлэх ёстой; 62–76, Тэд сайн мэдээг номлох ёстой, мөн тэмдгүүд дагалдах болно; 77–91, Ахлагчид үүргэвч

буюу түрийвчгүйгээр урагш одох ёстой, мөн Их Эзэн тэдний эрэлт хэрэгцээнд анхаарал тавих болно; 92–97, Сайн мэдээг эсэргүүцдэг тэдэнд өвчин тахлууд хийгээд зүхлүүд тохиох болно; 98–102, Сионы гэтэлгэлийн шинэ магтуу өгөгдөв; 103–110, Хүн болгон албан тушаалд үүргээ биелүүлж мөн дуудлагдаа хөдөлмөрлөг; 111–120, Их Эзэний үйлчлэгчид эцсийн өдрүүдийн үгүйрлийн жигшүүрт хэргийг тунхаглах ёстой.

ӨӨРИЙН үйлчлэгч Бага Иосеф Смит мөн зургаан ахлагчид, зүрх сэтгэлээ нэгтгэж, тэнгэрт дуу хоолойгоо “өргөхөд өгсөн Есүс Христийн илчлэлт оршвой.

4а Мозая 4:14.
5а С ба Г 78:3.
су Агуулах.

6а су Бэлэвсэн.
б Мозая 4:16–26;
Хил. 4:11–13;

С ба Г 42:30–39.
су Ядуус.
84 1а су Залбирал.

2 Тийм ээ, “Шинэ Иерусалим хот байх Сионы ⁶Уулан дээр зогсох өөрийн ⁶гэгээнтнүүдийг цуглуулахын тулд, мөн өөрийн хүмүүсийг ⁶сэргээхийн тулд тэрээр ⁶бошиглогчдынхоо амаар хэлсэнчлэн, эцсийн өдрүүдэд байгуулсан өөрийн сүмийн талаарх Их Эзэний үг оршвой.

3 Миссури муж улсын өрнөд хязгаарт, Их Эзэний хуруугаар тогтоогдсон, мөн Бага Иосеф Смит болон Их Эзэний таалалд нийцсэн бусад тэднээр онцгойлон адислагдсан “ариун сүмийн газрын эхлэлд баригдах тэр хот буюу.

4 Үнэнээр, бүр энэ үед босгогдох тэрхүү ариун сүм болох “ариун сүмийн газарт, энэ газарт эхлэн, гэгээнтнүүдийн цугларалтаар баригдсан ⁶Шинэ Иерусалим хот байх болно хэмээх Их Эзэний үг болой.

5 Учир нь Их Эзэнд өргөө баригдаж, мөн уг өргөөг дүүргэх үүл, бүр Их Эзэний “алдар суу болох тэрхүү үүл үүн дээр амрах хүртэл үнэнээр энэ үеийнхэн бүгдээрээ алга болох нь үгүй.

6 Мөн Мосегийн хөвгүүд,

хадам эцэг “Иетрогийн ⁶гар дор тэрээр хүлээн авсан тэрхүү Ариун Санваарын дагуу;

7 Мөн Иетро үүнийг Каледын гар дор хүлээн авчээ;

8 Мөн Калед үүнийг Елайхугийн гар дор хүлээн авчээ;

9 Мөн Елайху Жеремийн гар дор;

10 Мөн Иеремиа Гадын гар дор;

11 Мөн Гад Есаиасын гар дор;

12 Мөн Есаиас үүнийг Бурханы гар дор хүлээн авчээ.

13 Есаиас тэрчлэн Абрахамын өдрүүдэд амьдарч байв, мөн түүгээр адислагдсан байжээ—

14 Бүр “Ноа хүртэл эцгүүдийнхээ удмаар дамжуулан үүнийг хүлээн авсан ⁶Мелкизедекээс ⁶Абрахам санваарыг хүлээн авчээ;

15 Мөн Ноагаас “Енох хүртэл эцгүүдийнхээ удмаар дамжуулан;

16 Мөн Енохоос, ахынхаа “хуйвалдаанаар егүүтгэгдсэн, анхны хүн асан өөрийн эцэг ⁶Адамын гараар, Бурханы зарлигуудаар санваарыг “хүлээн авсан ⁶Абелыг хүртэл—

17 Бурханы сүмд бүх үед үргэлжилдэг, мөн өдрүүдийн

2а Ифер 13:2–11;
С ба Г 42:8–9;
45:66–67;
ИТ 1:10.
су Шинэ Иерусалим.
б Иса. 2:2–5;
Евр. 12:22;
Илч. 14:1;
С ба Г 76:66; 84:32;
133:18, 56.
в су Гэгээнтэн.

г су Израил—
Израилын цугларалт.
д Үйлс 3:19–21.
3а С ба Г 57:3.
4а су Ариун Сүм, Их Эзэний өргөө.
б су Шинэ Иерусалим.
5а С ба Г 45:67;
64:41–43; 97:15–20;
109:12, 37.

6а су Иетро.
б су Гар тавих.
14а су Ноа, Библийн патриарх.
б су Мелкизедек.
в су Абрахам.
15а су Енох.
16а Мосе 5:29—32.
б су Адам.
в С ба Г 107:40–57.
г су Абел.

эхлэл буюу жилүүдийн төгсгөлгүй “санваар болой.

18 Мөн Их Эзэн “санваарыг тэрчлэн ^бАарон хийгээд түүний үр удам дээр, тэдний бүх үеийнхэнд нэвтэд нь баталсан бөлгөө, энэхүү санваар нь тэрчлэн Бурханы хамгийн ариун жаягийн дагуух санваартай үүрд үргэлжилж мөн үүрд хамт “үлдэх болно.

19 Мөн энэхүү дээд санваар нь сайн мэдээг удирдаж мөн хаант улсын “нууцуудын түлхүүрийг, бүр Бурханы ^бмэдлэгийн түлхүүрийг атгадаг болой.

20 Тиймийн тул, үүний “ёслолуудад бурханлиг чанарын хүч илэрхийлэгддэг.

21 Мөн үүний ёслолуудгүйгээр, мөн санваарын “эрх мэдэлгүйгээр, бурханлиг чанарын хүч махан бодид хүмүүнд илэрхийлэгдэх нь үгүй бөлгөө.

22 Учир нь үүнгүйгээр “хүмүүн Бурханы, бүр Эцэгийн нүүрийг үзэж, мөн амьдарч чадах нь үгүй.

23 Эдүгээ “Мосе аглаг буйдад Израилын хүүхдүүдэд үүнийг

тодорхойгоор заадаг байв, мөн тэд Бурханы нүүрийг ^бболгоож болохын тулд өөрийн хүмүүсийг “ариусгахын тулд хичээнгүйлэн эрэлхийлдэг байлаа;

24 Гэвч тэд зүрх сэтгэлээ “хатууруулж мөн түүний оршихуйг тэвчиж чаддаггүй байв; тиймийн тул, Их Эзэн ^бхилэгнэлдээ байв, учир нь түүний уур тэдний эсрэг дүрэлзэж байв, түүний алдар суугийн бүрэн байдал болох тэрхүү амралт, түүний амралтад тэд аглаг буйдад байхдаа “орохгүй хэмээн амласан билээ.

25 Тиймийн тул, тэрээр “Мосег, мөн Ариун ^бСанваарыг тэрчлэн тэдний дундаас гаргаж авчээ;

26 Мөн тэнгэр элчүүдийн “тохинуулал хийгээд бэлтгэл сайн мэдээний ^бтүлхүүрийг атгадаг доод “санваар үргэлжилж байв;

27 Уг сайн мэдээ нь “наманчлалын хийгээд ^ббаптисмын, мөн нүглүүдийн “ангжралын сайн мэдээ хийгээд эхийнхээ умайнаас эхлэн

17a Алма 13:1–19;
Абр. 2:9, 11.
су Мелкизедек санваар.

18a су Аароны санваар.
б су Аарон,
Мосегийн ах.
в С ба Г 13:1.

19a С ба Г 63:23;
107:18–19.
су Бурханы нууцууд.
б Абр. 1:2.

20a су Ёслолууд.
21a су Эрх мэдэл;

Санваартан.
22a С ба Г 67:11.
23a Ег. 19:5–11; 33:11.

б Ег. 24:9–11;
С ба Г 93:1.
в су Ариусгал.
24a Ег. 20:18–21; 32:8;
Дэд хууль 9:23;
1 Ниф. 17:30–31, 42.
б Дуул. 95:8;
Евр. 3:8–11;
Иаков 1:7–8;
Алма 12:36.
в iso, Ег. 34:1–2;
Тоол. 14:23;

Евр. 4:1–11.
25a Дэд хууль 34:1–5.
б су Мелкизедек санваар.

26a С ба Г 107:20.
б С ба Г 13:1.
в су Аароны санваар.
27a су Наманчлах,
Наманчлал.
б су Баптисм,
Баптисм хүртээх.
в су Нүглүүдийн ангжрал.

Ариун Сүнсээр 'дүүргэгдсэн байсан, Бурхан түүнийг бэлтгэсэн ^oИоханыг хүртэл Их Эзэн хилэгнэлдээ Израилын хүүхдүүдийн дунд Аароны угсааныханд үргэлжлүүлэхээр болгосон тэр ^ззуурдын зарлигуудын ^ххууль бөлгөө.

28 Учир нь тэрээр бүр хүүхэд ахуй үедээ баптисм хүртсэн байлаа, иудейчүүдийн хаант улсыг түлхэн унагаах, мөн Их Эзэний замыг түүний хүмүүсийн нүүрний өмнө "шулуун болгох, мутарт нь ^ббүх хүч өгөгдсөн Их Эзэний ирэлтэд тэднийг бэлтгэх энэхүү хүчинд түүнийг Бурханы тэнгэр элч томилоход, төрөөд найман өдөр болж байв.

29 Мөн дахин, аглагчдын хийгээд бишопын албан тушаалууд нь дээд санваарт харьяалагддаг "зайлшгүй хавсралтууд болой.

30 Мөн дахин, багш хийгээд диконы албан тушаалууд нь Аарон болон түүний хөвгүүдэд олгогддог байсан санваар, доод санваарт харьяалагддаг зайлшгүй хавсралтууд болой.

31 Тиймийн тул, Мосегийн хөвгүүдийн талаар миний хэлсний дагуу— Мосегийн

хөвгүүд хийгээд тэрчлэн Аароны хөвгүүдийн хувьд энэ үед, миний тогтоосон тэрхүү ариулагдсан "газарт Их Эзэнд баригдах өргөө болох Их Эзэний өргөөнд хүлээн авч болохуйц ^өөргөл болон золиослолыг өргөх ёстой—

32 Мөн та нар хөвгүүд нь болох, Мосегийн хөвгүүд хийгээд Аароны хөвгүүд Сионы "Уулан дээр, Их Эзэний өргөөнд Их Эзэний ^аалдар суугаар дүүргэгдэх болно; мөн тэрчлэн өөрийнхөө ^ссүмийг бариулахын тулд бибээр олныг дуудаж мөн урагш илгээсэн бөлгөө.

33 Учир нь миний ярьсан энэхүү хоёр "санваарыг хүртэхэд, мөн дуудлагаа эрхэмлэн биелүүлэхэд ^иитгэлтэй байдаг хэн ч гэсэн, биеэ шинэчлэхийн тулд Сүнсээр ^аариусгагддаг бөлгөө.

34 Тэд Мосегийн хийгээд Аароны хөвгүүд мөн "Абрахамын ^уудам, мөн сүм ба хаант улс, мөн Бурханы ^ссонгосон хүмүүс болдог.

35 Мөн тэрчлэн энэхүү санваарыг хүлээн авдаг тэд бүгд намайг хүлээн авдаг хэмээн Их Эзэн хэлдэг;

36 Учир нь миний үйлчлэгч-

27_г Лук 1:15.

^д су Иохан Баптист.

^е Евр. 7:11–16.

^ё су Мосегийн хууль.

28_а Иса. 40:3;

Мат. 3:1–3;

Иохан 1:23.

^б Мат. 28:18;

Иохан 17:2;

1 Петр 3:22;

С ба Г 93:16–17.

29_а С ба Г 107:5.

31_а С ба Г 57:3.

^б С ба Г 128:24.

32_а Евр. 12:22;

С ба Г 76:66; 84:2;

133:56.

^б су Алдар суу.

^в су Есүс Христийн

Сүм.

33_а су Санваартан.

^б су Зөв зохистой,

Зөв зохистой

байдал.

^в су Ариусгал.

34_а С ба Г 132:30–32.

су Абрахамын гэрээ.

^б Гал. 3:29;

Абр. 2:9–11.

су Абрахам— Абрахамын үр удам.

^в су Сонгох.

дийг хүлээн авдаг тэрээр намайг “хүлээн авдаг болой;

37 Мөн намайг “хүлээн авдаг тэрээр Эцэгийг минь хүлээн авдаг болой;

38 Мөн Эцэгийг минь хүлээн авдаг тэрээр Эцэгийн минь хаант улсыг хүлээн авдаг; тиймийн тул Эцэгт минь байгаа “бүхэн түүнд өгөгдөх болно.

39 Мөн энэ нь санваарт хамаарагддаг “тангараг хийгээд гэрээний дагуу болой.

40 Тиймийн тул, санваарыг хүлээн авдаг тэд бүгд зөрчиж ч үл болох, мөн хөдөлгөж ч үл болох, Эцэгийн минь энэхүү тангараг хийгээд гэрээг хүлээн авдаг бөлгөө.

41 Гэвч үүнийг хүлээн авсныхаа дараа уг гэрээг “зөрчдөг, мөн үүнээс бүрмөсөн нүүр буруулах хэнд ч болов, энэ дэлхийд ч, мөн ирэх дэлхийд ч нүглүүдийн ^бөршөөл байх нь үгүй.

42 Мөн тэнгэрээс гарах миний өөрийн дуу хоолойгоор энэ өдөр ирээд байгаа өөрсдийн тань хүлээн авсан, та нарын дээр эдүгээ миний баталж байгаа энэхүү санваарт үл ирэх тэд бүгдэд халаг; мөн та нарт санаа тавих үүр-

гийг бүр тэнгэрийн түмэнд хийгээд “тэнгэр элчүүддээ би өгсөн билээ.

43 Мөн өөрсдөдөө санаа тавих, мөнх амьдралын үгсэд хичээнгүйлэн “анхаарал тавихдаа болгоомжтой байх зарлигийг бибээр эдүгээ та нарт өгч байна.

44 Учир нь та нар Бурханы амнаас урагш гардаг үг бүрээр “амьдрах ёстой.

45 Учир нь Их Эзэний “үг бол үнэн мөн ямар ч ^бүнэн нь гэрэл юм, мөн ямар ч гэрэл нь Сүнс, бүр Есүс Христийн Сүнс билээ.

46 Мөн Сүнс нь дэлхийд ирдэг “хүн болгонд ^бгэрлийг өгдөг; мөн Сүнс нь дэлхий даяар Сүнсний дуу хоолойг анхаардаг хүн болгоныг гэгээрүүлдэг бөлгөө.

47 Мөн Сүнсний дуу хоолойг анхаардаг хүн болгон Бурханд, бүр Эцэгт ирдэг болой.

48 Мөн Эцэг өөрийн шинэчилсэн хийгээд та нар дээр баталсан, та нарын тусын тулд, зөвхөн та нарын тусын тулд ч бус, харин бүхэл дэлхийн тусын тулд батлагдсан тэрхүү “гэрээний тухай түүнд ^бзаадаг.

49 Мөн бүхэл “дэлхий нүгэлд

36a Мат. 10:40–42;

Лук 10:16;

С ба Г 112:20.

37a Иохан 13:20.

38a Лук 12:43–44;

Ром 8:32;

Илч. 21:7;

3 Ниф. 28:10;

С ба Г 132:18–20.

су Өргөмжлөл.

39a су Санваарын

тангараг ба гэрээ.

41a су Урвалт.

б С ба Г 76:34–38;

132:27.

42a С ба Г 84:88.

43a 1 Ниф. 15:23–25;

С ба Г 1:14.

44a Дэд хууль 8:3;

Мат. 4:4;

С ба Г 98:11.

45a Дуул. 33:4.

су Бурханы Үг.

б су Үнэн.

46a Иохан 1:9;

С ба Г 93:2.

б су Ухамсар; Гэрэл,

Христийн гэрэл.

48a су Гэрээ; Шинэ

бөгөөд үүрдийн

гэрээ.

б су Сүнсний

удирдамж,

Сүнслэгээр

нөлөөлөгдөх.

49a 1 Иохан 5:19.

байна, мөн ^бхаранхуйн дор мөн нүглийн боолчлол дор ёлно.

50 Мөн тэд “нүглийн ^ббоолчлол дор байгааг үүгээр та нар мэдэж болно, учир нь тэд надад ирдэггүй бөлгөө.

51 Учир нь надад үл ирдэг хэн ч гэсэн нүглийн боолчлол дор байдаг билээ.

52 Мөн миний дуу хоолойг үл хүлээн авах хэн ч гэсэн, миний “дуу хоолойг таньдаггүй, мөн надаас бус юм.

53 Мөн үүгээр та нар зөв шударга хүмүүсийг ёс бусчуудаас ялган таньж мөн бүхэл “дэлхий ^бнүгэлд мөн бүр эдүгээ харанхуй дор ^өёолж буйг мэдэх болно.

54 Мөн “итгэлгүйн улмаас, мөн та нар өөрсдийнхөө хүлээн авсан зүйлүүдэд хөнгөмсгөөр хандсаны улмаас та нарын оюун өнгөрсөн үед харанхуйлагдсан байлаа —

55 Энэхүү “хоосон болон итгэлгүй байдал нь бүхэл сүмийг буруушаалт дор авчирсан буюу.

56 Мөн энэхүү буруушаалт Сионы хүүхдүүд, бүр бүгд дээр байна.

57 Мөн тэд наманчилж мөн тэрхүү шинэ “гэрээ, бүр ^бМормоны Номыг мөн тэдэнд миний өгсөн ^өурьдын зарли-

гуудыг зөвхөн хэлэхээр төдийгүй, харин миний бичсэн ний дагуу ‘үйлдэхээр дурсан санах хүртэл тэд энэхүү буруушаалт дор үлдэх болно—

58 Тэд Эцэгийнхээ хаант улсад тохирох үр жимсийг урагш авчирч болохын тулд буюу; эс бөгөөс Сионы хүүхдүүд дээр цутгагдах цээрлүүлэлт хийгээд шүүлт хэвээр үлдэх болно.

59 Учир нь хаант улсын хүүхдүүд миний ариун нутгийг бохирлох уу? Үнэнээр би та нарт хэлнэ, Үгүй.

60 Үнэнээр, үнэнээр бибээр, миний дуу хоолой болох “үгсийг минь эдүгээ сонсож буй та нарт хэлж байна, та нар эдгээр зүйлүүдийг хүлээн авахын хэрээр адислагдсан болой та нар;

61 Учир нь та нар оюундаа “чанд байдалд хийгээд залбирлын сүнсэнд өөрсөдтэйгөө холбогдсон тэдгээр зүйлүүдийг бүх дэлхийд гэрчлэхэд гуйвшгүй хэвээр үлдэхийн тулд энэхүү зарлигаар бибээр нүглүүдийг чинь та нарт ^бөршөөх болно.

62 Тиймийн тул, та нар бүх дэлхийгээр “явагтун; мөн уг гэрчлэл та нараас бүх дэлхийд хүн болгонд очиж болохын тулд та нар явж үл чадах

49б су Сүнсний харанхуй.

50а су Нүгэл. б Гал. 4:9.

52а Иохан 10:27.

53а су Дэлхий. б су Дэлхийнх.

в Ром. 8:22; Моисе 7:48.

54а су Итгэлгүй байдал.

55а су Хоосон үг, Хоосон үг ярих.

57а Иер. 31:31–34.

б су Мормоны Ном.

в 1 Ниф. 13:40–41.

г Иаков 1:22–25;

С ба Г 42:13–15.

60а С ба Г 18:34–36.

61а С ба Г 43:34;

88:121; 100:7.

б Дан. 9:9.

су Уучлах.

62а Марк 16:15;

С ба Г 1:2–5.

су Номлолын ажил.

аливаа газарт гэрчлэлээ илгээх ёстой.

63 Мөн бибээр төлөөлөгчиддөө хэлсэнчлэн, бүр та нарт би үүнчлэн хэлж байна, учир нь та нар миний “төлөөлөгчид, бүр Бурханы дээд санваартнууд билээ; та нар бол Эцэгийн минь надад ^бөгсөн тэд юм; та нар миний “найз нар билээ;

64 Гиймийн тул, бибээр төлөөлөгчиддөө хэлсэнчлэн бибээр та нарт дахин хэлж байна, та нарын үгст “итгэдэг мөн нүглүүдийн ^бангжралын төлөө усаар баптисм хүртдэг ^сүнс бүр ^аАриун Сүнсний хүлээн авах болно.

65 Мөн эдгээр “тэмдгүүд итгэдэг тэднийг дагалдах болно —

66 Миний нэрээр тэд олон гайхамшигт “ажлыг хийх болно;

67 Миний “нэрээр тэд чөтгөрүүдийг зайлуулах болно;

68 Миний нэрээр тэд өвчтөнүүдийг “эдгээх болно;

69 Миний нэрээр тэд хараагүйчүүдийн нүдийг нээж, мөн дүлийчүүдийн чихний бөглөөсийг гаргах болно;

70 Мөн хэлгүйчүүдийн хэл ярих болно;

71 Мөн хэн нэгэн нь тэдэнд

“хор өгөх аваас энэ нь тэднийг гэмтээхгүй байх болно;

72 Мөн хорт могойн хор тэднийг хөнөөх хүчгүй байх болно.

73 Гэвч эдгээр зүйлүүдээр тэд өөрсдөө “сагсуурах ч, мөн дэлхийн өмнө тэдгээрийг ярих ч ёсгүй хэмээх зарлигийг би тэдэнд өгч байна; учир нь эдгээр зүйлүүд та нарын ашиг тус хийгээд авралын төлөө та нарт өгөгдсөн бөлгөө.

74 Үнэнээр, үнэнээр би та нарт хэлж байна, та нарын үгсэд эс итгэдэг, мөн Ариун Сүнсний хүлээн авч болохын тулд мөн миний нэрээр, нүглүүдийнхээ ангжралын тулд усанд “баптисм хүртээгүй тэд ^бяллагдах болно, мөн миний Эцэг хийгээд бибээр оршдог Эцэгийн минь хаант улсад ирэхгүй байх болно.

75 Мөн та нарт өгөх энэхүү илчлэлт, мөн зарлиг нь яг энэ цагаас бүх дэлхийд хүчин төгөлдөр бөлгөө, мөн сайн мэдээ нь үүнийг хүлээн аваагүй тэд бүгдэд очдог бөлгөө.

76 Гэвч хаант улс өгөгдсөн тэд бүгдэд бибээр үнэнээр хэлж байна — тэд урьдах хилэнцэт ажлуудаасаа наман-

63a су Төлөөлөгч.

б 3 Ниф. 15:24;

С ба Г 50:41–42.

в Иохан 15:13–15;

С ба Г 93:45.

64a Марк 16:15–16.

су Итгэлтэй байх, Итгэл.

б су Нүглүүдийн

ангжрал.

в су Бодгаль

г су Ариун Сүнсний бэлэг.

65a Марк 16:17–18.

су Тэмдэг.

66a су Ажлууд.

67a Мат. 17:14–21.

68a су Эдгээх, Эдгэрэх.

71a Марк 16:18;

Үйлс 28:3–9;

С ба Г 24:13;

124:98–100.

73a С ба Г 105:24.

су Бардамнал.

74a 2 Ниф. 9:23;

С ба Г 76:50–52.

су Баптисм,

Баптисм хүртээх—

Чухал шаардлага.

б Иохан 3:18.

чилж болохын тулд энэ нь та нараас тэдэнд номлогдох ёстой; учир нь тэд итгэлгүй хилэнцэт зүрх сэтгэлийнхээ улмаас, мөн Сион дахь та нарын ах дүүс та нарыг би илгээсэн үед та нарыг эсэргүүцэний төлөө зэмлэгдэх ёстой.

77 Мөн дахин би та нарт хэлж байна, найз нар минь, учир нь энэ цагаас хойш та нарыг бибээр найз нараа хэмээн дуудна, бибээр тэдэнтэй хамт байж тэр өдрүүд сайн мэдээг сүр хүчиндээ номлохоор аялж байсан миний найз нарын адил бол та нар, хэмээх энэхүү зарлигийг бибээр та нарт өгөх нь зүйтэй байна;

78 Учир нь тэдэнд “мөнгөний хэтэвч буюу аяны цүнх мөн хоёр цув байхыг би үл хүлцсэн болой.

79 Болгоогтун, дэлхийд нотлохын тулд би та нарыг илгээж байна, мөн хөдөлмөрлөгч нь “хөлс шангаа хүртэх нь зохистой бөлгөө.

80 Мөн явж хаант улсын энэхүү “сайн мэдээг” тунхаглах, мөн бүх зүйлд итгэлтэйгээ үргэлжлүүлэхэд бүтэлгүйтэхгүй аль ч хүмүүн оюундаа харанхуйлагдах нь үгүй, мөн биендээ ч, үендээ ч, мөчиндөө ч тэр ядарсан байх нь үгүй; мөн толгойнх нь нэг

ширхэг “үс ч газарт ажиглагдахааргүй унах нь үгүй билээ. Мөн тэр өлсгөлөн явах нь ч, мөн цангах нь ч үгүй байх болно.

81 Тиймийн тул, маргаашийн төлөө, та нар юу идэхийнхээ, эсвээс та нар юу уухынхаа, эсвээс юугаар та нар хувцаслагдсан байхынхаа төлөө та нар “санаа бүү зов.

82 Учир нь талбайн нил цэцгүүд хэрхэн ургадгийг ажигла, тэдгээр нь хөдөлмөрлөдөггүй, тэдгээр нь нэхдэг ч үгүй болой; мөн дэлхийн хаант улсууд, бүхий л алдар суундаа эдгээрийн нэгнийх нь ч адил хувцасладаггүй билээ.

83 Учир нь тэнгэрт байдаг та нарын “Эцэг, эдгээр бүх зүйлд та нарт хэрэгтэйг” мэддэг билээ.

84 Тиймийн тул, маргаашийн зүйлүүдийн талаар маргааш нь “санаа тавиг.

85 Мөн та нар “юу хэлэхээ урьдаас бүү бод; харин амьдралын үгсийг оюундаа ямагт” нөөцөл, мөн хүн болгонд хэмжигдэх тэрхүү хэсэг нь яг тэр цагт та нарт “өгөгдөх болно.

86 Тиймийн тул, хаант улсын энэхүү сайн мэдээг тунхаглахаар урагш одох та нарын дундах ямар ч хүн энэ

78a Мат. 10:9–10;
С ба Г 24:18.

79a С ба Г 31:5.

80a су Сайн мэдээ.
б су Номлолын ажил.
в Лук 21:18.

81a Мат. 6:25–28.

83a су Тэнгэр дэх Эцэг.

б Мат. 6:8.

84a Мат. 6:34.

85a Мат. 10:19–20;

Лук 12:11–12;

С ба Г 100:6.

б 2 Ниф. 31:20;

Алма 17:2–3;

С ба Г 6:20; 11:21–26.

су Тунгаан бодох.

в су Заах, Багш—

Сүнсээр заах.

цагаас эхлэн түрийвч буюу мөнгө бүү авч яваг, учир нь энэхүү зарлиг нь тохинуулалд Бурханаас сүмд дуудагддаг “итгэлтэй тэд бүгдэд зориулагдсан бөлгөө.

87 Болгоогтун, дэлхийг тэдний бүхий л шударга бус зүйлүүдийнх нь төлөө зэмлэхийн тулд мөн ирэх шүүлтийн тухай тэдэнд заахын тулд бибээр та нарыг “илгээж байна.

88 Мөн та нарыг хэн ч “хүлээн авлаа гэсэн, тэнд би тэрчлэн байх болно, учир нь би та нарын нүүрний өмнө явах болно. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно, мөн миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн миний ^бтэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно.

89 Та нарыг хүлээн авдаг хэн ч гэсэн намайг хүлээн авдаг бөлгөө; бас мөнхүү тэд та нарыг хооллож мөн та нарыг хувцаслаж, мөн та нарт мөнгө өгөх болно.

90 Мөн та нарыг хооллох, эсвээс та нарыг хувцаслах, эсвээс та нарт мөнгө өгөх тэрээр, яавч шагналаа “алдах учиргүй.

91 Мөн эдгээр зүйлүүдийг үл хийх тэрээр миний шавь биш бөлгөө; үүгээр нь та нар

“миний шавь нарыг мэдэж болох авай.

92 Та нарыг үл хүлээн авдаг түүнээс та нар дангаараа өөрсдөө холдон явагтун, мөн бүр халуунд ч, эсвээс хүйтэнд ч усаар, бүр цэвэр усаар хөлөө “цэвэрлэ, мөн энэ тухай тэнгэр дэх Эцэгтээ гэрчил, мөн тэр хүн дээр дахин эргэж бүү оч.

93 Мөн ямар ч тосгон буюу хотод та нар орлоо гэсэн, үүний адилаар үйлдэгтүн.

94 Гэсэн хэдий ч, хичээнгүйлэн эрж хайгтун мөн бүү татгалз; мөн та нарыг, эсвээс та нарын үгсийг, эсвээс миний тухай гэрчлэлийг тань эсэргүүцэх тэр айлд, эсвээс тэр тосгонд буюу хотод халаг.

95 Би дахин хэлж байна, та нарыг эсвээс та нарын үгсийг, эсвээс миний тухай гэрчлэлийг тань няцаах тэр айлд, эсвээс тэр тосгонд буюу хотод халаг;

96 Учир нь “Бүхнийг Чадагч бибээр тэдний ^бёс бусын учир тэдэнд “цээрлэл тохиолгохоор үндэстнүүд дээр гараа тавьсан билээ.

97 Мөн тахал тархах болно, мөн зөв шударга ёсонд “түргэссэн байх ёстой өөрийн ажлыг намайг дуусгах хүртэл тэдгээр нь дэлхийгээс авагдах нь үгүй—

86a Мат. 24:44–46;
С ба Г 58:26–29;
107:99–100.

87a су Номлолын
ажил.

88a Мат. 10:40;
Иохан 13:20.

б С ба Г 84:42.
су Тэнгэр элчүүд.

90a Мат. 10:42;
Марк 9:41.

91a Иохан 13:35.

92a Мат. 10:14;
Лук 9:5;

С ба Г 60:15.

96a су Бүхнийг Чадагч.
б су Ёс бус, Ёс бус
байдал.

в С ба Г 1:13–14.

97a Мат. 24:22.

98 Бүр хамгийн дордоосоо хамгийн агууг хүртэл үлдэх тэд бүгд намайг мэдэх хүртэл мөн Их Эзэний тухай мэдлэгээр дүүргэгдэж мөн “нүдээр үзэх болно, мөн дуу хоолойгоо өргөх болно, мөн тэрхүү дуу хоолойгоор энэхүү шинэ дууг хамтдаа ^бдуулж, хэлэх нь:

99 Их Эзэн Сионыг дахин авчирлаа;

Их Эзэн өөрийн хүмүүс, “Израилыг ^бгэтэлгэлээ,

Итгэлээр мөн тэдний эцгүүдийн ^агэрээгээр улиран тохиогдохоор авчрагдсан ‘Ач ивээлийн ^асонголтын дагуу буюу.

100 Их Эзэн өөрийн хүмүүсийг гэтэлгэлээ;

Ийн Сатан “хүлэгдсэн болой мөн цаг хугацаа дахиад байхгүй.

Их Эзэн бүх зүйлийг ^бнэгд цуглууллаа.

Их Эзэн “Сионыг дээрээс доош аваачлаа.

Их Эзэн Сионыг доороос дээш ‘аваачлаа.

101 “Дэлхий дуншиж мөн хүч чадлаа урагш авчирлаа;

Мөн үнэн үүний хэвлийд үндэслэгдэн бий боллоо;

Мөн тэнгэр түүн дээр инээмсэглэв;

Мөн тэрээр Бурханыхаа ^балдар суугаар хувцаслажээ; Учир нь тэрээр өөрийн хүмүүсийн дунд зогсох бөлгөө.

102 Алдар суу, мөн хүндэтгэл, мөн сүр хүч, мөн чадал,

Бидний Бурханд оршин байх болтугай; учир нь тэрээр “нигүүлсэл,

Шударга ёс, мөн ач ивээл, мөн үнэн, мөн ^бамар амгалангаар,

Үүрд мөн мөнхөд дүүрэн болой, Амен.

103 Мөн дахин үнэнээр, үнэнээр би та нарт хэлж байна, миний үүрдийн сайн мэдээг тунхаглахаар урагш одох хүн бүр, тэд гэр бүлтэй байхын, мөн бэлгээр мөнгө хүлээн авахын хэрээр Их Эзэн намайг өөрсдийг нь удирдан чиглүүлснээр үүнийг тэдэнд илгээх, эсвээс тэдний тусын тулд ашиглах нь зүйтэй болой, учир нь ийнхүү энэ нь надад сайн санагдах ажгуу.

104 Мөн гэр бүлгүй, “мөнгө хүлээн авах тэд бүгд илчлэлтийг урагш авчрахын тулд мөн тэдгээрийг хэвлэхийн тулд, мөн Сионыг байгуулахын тулд энэ нь ариулан адислагдаж болохын тулд үүнийг Сион дахь бишопт,

98a Иса. 52:8.

б Дуул. 96:1;

Илч. 15:3;

С ба Г 25:12; 133:56.

сү Дуулах.

99a сү Израил.

б Илч. 5:9;

С ба Г 43:29.

в сү Абрахамын

гэрээ.

г сү Ач ивээл.

д сү Сонгогдогсод.

100a Илч. 20:2–3;

С ба Г 43:31; 45:55;

88:110.

б Ефес 1:10;

С ба Г 27:13.

в С ба Г 45:11–14;

Моисе 7:62–64.

сү Сион.

г С ба Г 76:102; 88:96.

101a сү Газар дэлхий.

б сү Алдар суу.

102a сү Нигүүлсэнгүй,

Нигүүлсэл.

б сү Амар амгалан.

104a С ба Г 51:8–9, 12–13.

эсвээс Огайо дахь бишопт илгээг.

105 Мөн хэн нэгэн нь та нарын хэн нэгэнд цув, эсвээс костюм өгөх аваас хуучныгаа авч яваад мөн үүнийгээ “ядууст өгөөд мөн замаараа баясан одогтун.

106 Мөн хэрэв та нарын дунд хэн нэгэн нь Сүнсэнд хүчтэй байх аваас, тэрээр сул дорой болох түүнийг, тэрээр бүхий л “номхон дөлгөөн байдалд сэнхэрч болохын тулд, тэрээр тэрчлэн хүчирхэг болж болохын тулд өөртэйгөө хамт авч ^бяваг.

107 Тиймийн тул, “доод санваарт томилогддог тэднийг өөрсөдтэйгөө хамт авч яв, мөн тэднийг өөрсдийнхөө өмнө уулзалтыг товлуулахаар мөн замыг бэлтгэхээр, мөн та нар өөрсдөө хийх боломжгүй товлогдсон уулзалтуудыг хийлгүүлэхээр илгээгтүн.

108 Болгоогтун, энэ бол эрт дээр үед миний төлөөлөгчид миний сүмийг надад өсгөн бэхжүүлдэг байсан тэрхүү зам бөлгөө.

109 Тиймийн тул, хүн болгон албан тушаалдаа үүргээ биелүүлж мөн дуудлагадаа хөдөлмөрлөг; мөн толгой нь хөл өөрт нь хэрэггүй хэмээн бүү хэлэг; учир нь хөлгүйгээр бие хэрхэн зогсож чадах билээ?

110 Тэрчлэн бүгд хамтдаа сэнхэрч болохын тулд, тогтолцоо нь төгс хадгалагдаж болохын тулд биенд “эрхтэн бүр хэрэгтэй.

111 Мөн болгоогтун, “дээд санваартнууд, тэрчлэн ахлагчид мөн тэрчлэн ^бдоод санваартнууд аялах ёстой; харин ^адиконууд мөн ^вбагш нар сүмийг ^ахарж хандахын тулд сүмд байнга ажилладаг тохинуулагчид байхаар томилогдох ёстой.

112 Мөн бишоп Ньюел К.Витней баячууд хийгээд бардамнагчдыг “даруусгаснаар тэдний хүслүүдэд ^бтуслахын тулд ядуусыг эрж, тэрчлэн эргэн тойрондоо мөн сүмүүдийн дунд аялах ёстой.

113 Өөрийнхөө материаллаг ажлуудыг түүний зааварласны дагуу хийх мөн хариуцаж байх “төлөөний хүнийг тэрээр тэрчлэн ажилд авах ёстой.

114 Гэсэн хэдий ч, бишоп Нью-Йорк хот уруу, тэрчлэн Албани хот уруу, тэрчлэн Бостон хот уруу явж, мөн тэдгээр хотуудын хүмүүст, хэрэв тэд эдгээр зүйлүүдийг няцаах аваас, тэднийг хүлээж буй “эзгүйрэл хийгээд бүрэн сүйрлийн тухай сайн мэдээнний дуугаар, чанга дуу хоолойгоор сэрэмжлүүлэх ёстой.

115 Учир нь хэрэв тэд эдгээр зүйлүүдийг няцаах аваас, тэд-

105a су Ядуу—Эд агуурсаар ядуу байх.

106a су Номхон дөлгөөн, Номхон дөлгөөн байдал.
б су Нөхөрлөл.

107a су Аароны

санваар.
110a 1 Кор. 12:12–23.

111a су Дээд санваартан.
б су Санваартан, Аароны санваар.
в су Дикон.

г су Багш, Аароны санваар.
д су Харах, Харуул.
112a С ба Г 56:16.
б су Халамж.
113a С ба Г 90:22.
114a С ба Г 1:13–14.

ний шүүлтийн цаг ойрхон байна, мөн тэдний гэр орон тэдэнд “эзгүйрэн хоцрох болно.

116 Тэрээр надад “найздаг байг мөн тэрээр ⁶мэдлуулах нь үгүй; мөн түүний нэг ширхэг ⁶үс ч ажиглагдалгүйгээр газарт унахгүй байх болно.

117 Мөн үнэнээр би та нарт хэлнэ, миний үйлчлэгчдээс үлдсэн та нар нөхцөл байдал чинь боломжтой болох үед, тэдний бүх зөв шударга бус хийгээд бурханлиг бус үйлүүдийн талаар дэлхийг зөв шударгаар зэмлэж, эцсийн өдрүүд дэх жигшүүрт байдлын эзгүйрлийг тодорхой бөгөөд ойлгомжтойгоор танилцуулан, тэрхүү агуу хийгээд чухал хотуудад өөрсдийн

хэд хэдэн дуудлагад урагш одогтун.

118 Учир нь Бүхнийг Чадагч Их Эзэн бибээр та нараар дамжуулан тэдний хаант улсуудыг “бутлан сөнөөх болно хэмээн хэлж байна; бибээр зөвхөн газрыг ⁶хөдөлгөх төдийгүй, харин одод дүүрэн тэнгэрийг чичрэх болгоно.

119 Учир нь Их Эзэн бибээр тэнгэрийн хүчийг үзүүлэхээр гараа тавьсан билээ; та нар үүнийг эдүгээ харж чадахгүй, хэсэгхэн хугацаа болоод мөн та нар үүнийг харах болно, мөн би байдгийг мэдэх болно, мөн би “ирж мөн өөрийн хүмүүстэй хамт ⁶хаанчлах болно.

120 Би бол “Альфа ба Омега, эхлэл ба төгсгөл. Амен.

ХЭСЭГ 85

1832 оны арваннэгдүгээр сарын 27-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой. (History of the Church, 1:298–299). Энэ хэсэг бол Миссурийн Индепендент амьдарч асан В.В.Феллст Бошиглогчийн бичсэн захидлаас авсан хэсэг юм. Сионд шилжин очсон бөгөөд Сүмд тогтсон журмын дагуу өөрсдийн өвийг хүлээн аваагүй тэдгээр гэгээнтнүүдийн талаарх асуултад энэ нь хариулахаар өгөгдсөн ажээ.

1–5, Сион дахь өвүүд өргөлөөр хүлээн авагдах ёстой; 6–12, Хүчтэй хийгээд хүчирхэг нэгэн Сионд Гэгээнтнүүдэд өвийг нь өгөх болно.

ЭНЭ бол Сионд болж буй бүх зүйлийн тухай мөн өмч хөрөнгийг “ариулан адисладаг, мөн өвийг бишопоос хууль ёсны дагуу хүлээн авдаг

115a Лук 13:35.

116a су Итгэл.

б Дуул. 22:5;

1 Петр 2:6.

в Мат. 10:29–31.

118a Дан. 2:44–45.

б Иоел 2:10;

С ба Г 43:18; 45:33,

48; 88:87, 90.

су Эцсийн

өдрүүд, Хожмын

өдрүүд; Цаг

хугацааны

тэмдгүүд.

119a С ба Г 1:12, 35–36;

29:9–11; 45:59.

су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

б су Мянган жил.

120a су Альфа ба

Омега.

85 1a С ба Г 42:30–35.

тэд бүгдийн тухай түүх, мөн сүмийн ерөнхий ^бцэдэг хөтлөхөөр түүний томилсон, Их Эзэний бичиг хэргийн ажилтны үүрэг юм;

2 Мөн тэдний амьдрал, тэдний итгэл, мөн ажлуудын хэв маягийн тухай болой; мөн тэрчлэн өөрсдийн өвийг хүлээн авсны дараа урвадаг урвагчдын тухай болой.

3 Тэрээр өөрийн хүмүүст “аравны нэгийг оноож, ^бөс хонзон хийгээд шатаалтын өдрийн эсрэг тэднийг бэлтгэхийн тулд өгсөн түүний хуулийн дагуу ^аөргөлөөр өвийг хүлээн авдаггүй тэд, Бурханы хүмүүстэй хамт өөрсдийн нэрсийг цэдэглэх ёстой нь Бурханы таалал хийгээд зарлигт харш юм.

4 Мөн тэдний удмын бичиг хадгалагдах буюу сүмийн аливаа цэдгүүдэд, эсвээс түүхэнд энэ нь олддог байх ёсгүй.

5 Тэдний нэрс олддог байх ёсгүй, мөн эцгүүдийнх нь нэрс, бас хүүхдүүдийнх нь нэрс ч Бурханы хуулийн “номонд бичигдэх ёсгүй хэмээн Түмний Их Эзэн хэлдэг.

6 Тийм ээ, бүх зүйлийг нэвт мөн “цоо хатган шивнэдэг мөн олонтаа энэ нь илэрхийлэхэд ясыг минь чичрэх бол-

годог ^бнамуухан аниргүй дуу хоолой ийн хэлдэг:

7 Мөнхүү улиран тохиох дор сүр хүчний очирт таягийг гартаа барьж, гадуураа гэрлийг өмссөн, ам нь үгсийг, мөнхийн үгсийг илэрхийлэх хүчтэй хийгээд хүчирхэг нэгийг Их Эзэн бибээр илгээх болно; түүнчлэн Бурханы өргөөг эмх цэгцэд барихын тулд мөн Бурханы хуулийн номонд нэрс нь, мөн эцгүүдийнх нь нэрс, мөн хүүхдүүдийнх нь нэрс олддог гэгээнтнүүдийн өвийг хэсэгчлэн байгуулахын тулд, түүний хэвлий үнэний оргилуур байх болно;

8 Харин Бурханаас дуудагдаж мөн томилогдсон, Бурханы “авдрыг тогтвортой болгохоор гараа урагш сунгах тэр хүн, аянгын хурц цахилтаар арчигдан унах мод лугаа адил үхлийн дайралтаар унах болно.

9 Мөн дурсамжийн “номонд бичигдсэн нь үл олддог тэд бүгд тэр өдөр ямар ч өвийг олох нь үгүй, харин тэд тас цавчигдах болно, мөн тэдний хувь нь ^бёолж мөн шүдээ хавирах үл итгэгчдийн дунд өгөгдөх болно.

10 Эдгээр зүйлүүдийг би өөрөөсөө хэлээгүй болой; тиймийн тул, Их Эзэн хэлсэн

<p>1б С ба Г 21:1; 47:1; 69:3–6. 3а су Аравны нэг төлөх, Аравны нэг. б Малах. 3:10–11, 17; С ба Г 97:25–26. в су Өргөл болгох,</p>	<p>Өргөлийн хууль. 5а су Амьдралын Ном. 6а Евр. 4:12. б Хаад. дээд 19:11–12; Хил. 5:30–31; 3 Ниф. 11:3–7. 8а 2 Сам. 6:6–7;</p>	<p>Шаст. дээд 13:9–10. су Гэрээний авдар. 9а 3 Ниф. 24:16; Мосе 6:5–6. су Дурсамжийн ном. б С ба Г 19:5.</p>
--	--	---

л бол, тэрбээр тэрчлэн бие-
лүүлэх болно.

11 Мөн нэрс нь хуулийн “но-
монд бичигдсэн нь үл олд-
дог Дээд санваартан тэд, эс-
вээс ^бурвасан нь олдсон буюу
сүмээс ^атусгаарлагдсан тэд,
түүнчлэн доод санваартан
тэд, эсвээс гишүүд, тэр өдөр

Бүхнээс Дээдийн Гэгээнт-
нүүдийн дунд өв олох нь
үгүй болой;

12 Тиймийн тул, энэ нь Езра-
гийн хоёрдугаар бүлэг мөн
жаран нэг мөн жаран хоёр
дахь шүлгүүдэд цэдэглэгдсэн
санваартны хүүхдүүдийн ади-
лаар тэдэнд хийгдэх болно.

ХЭСЭГ 86

1832 оны арванхоёрдугаар сарын 6-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршовой (History of the Church, 1:300). Бошиглогч Библийн орчуулгын гар бичмэлийг хянан тохиолдуулж байх үед энэхүү илчлэлт хүлээн авагджээ.

1–7, Улаан буудай хийгээд зэрлэг
өвснүүдийн тухай сургаалт
зүйрлэлийн утгыг Их Эзэн өгдөг;
8–11, Махан бодийнхоо дагуу
хууль ёсны залгамжлагчид болох
тэдэнд ирдэг санваарын адисла-
луудын талаар тэрбээр тайл-
барладаг.

ҮНЭНЭЭР, Их Эзэн, улаан
буудай хийгээд зэрлэг
өвснүүдийн тухай ^асургаалт
зүйрлэлээр шавь нартаа ийн
хэлдэг:

2 Болгоогтун, үнэнээр би
хэлдэг, талбай нь дэлхий
байсан болой, мөн төлөөлөг-
чид нь үр суулгагчид байсан
бөлгөө;

3 Мөн тэд нойрссоны дараа
мөнөөх урвагч, янхан, бүх
үндэстнийг өөрийн аяганаас

уух болгодог, зүрх сэтгэлд
нь дайсан, бүр Сатан хаанч-
лахаар суудаг, бүр “Вавилон,
сүмийг агуу ихээр мөрдөн
хавчигч тэрээр хогийн урга-
мал суулгадгийг болгоогтун;
иймийн тул, зэрлэг өвснүүд
нь улаан буудайг багалзуур-
даж мөн ^бсүмийг аглаг буйд
уруу хөөдөг ажгуу.

4 Гэвч болгоогтун, “эцсийн
өдрүүдэд, бүр эдүгээ Их Эзэн
үгийг урагш авчирч эхэлж
байна, мөн нахиа нь соёолж
мөн нялхаараа байна.

5 Болгоогтун, үнэнээр би та
нарт хэлж байна, талбайнуу-
дыг “хадахаар урагш илгээг-
дэхэд бэлэн байгаа бөгөөд
хүлээж буй ^бтэнгэр элчүүд
өдөр мөн шөнө Их Эзэнд
хашгирч байна;

11а су Амьдралын
ном.
б су Урвалт.
в су Сүмээс хөөх.
86 1а Мат. 13:6–43;

С ба Г 101:64–67.
3а Илч. 17:1–9.
су Бабел, Вавилон.
б Илч. 12:6, 14.
4а су Эцсийн өдрүүд,

Хожмын өдрүүд.
5а су Ургац хураалт.
б С ба Г 38:12.

6 Гэвч Их Эзэн тэдэнд хэлнэ, та нар улаан буудайг тэрчлэн устгахгүйн тулд нахиа нь нялхаараа байгаа үед зэрлэг өвснүүдийг бүү сугалж хая, (учир нь үнэнээр та нарын итгэл сул байна).

7 Тиймийн тул, улаан буудай хийгээд зэрлэг өвснүүд нь ургац бүрэн боловсрох хүртэл хамтдаа ургаг; дараа нь та нар эхлээд улаан буудайг зэрлэг өвснүүдээс ялган цуглуулж авах ёстой, мөн улаан буудайг цуглуулсны дараа болгоож мөн харагтун, зэрлэг өвснүүд боодлуудад боогдох болно, мөн талбай нь шатаагдахаар үлддэг бөлгөө.

8 Тиймийн тул, та нарын эцгүүдийн удмаар дамжин “санваар үргэлжлэн ирсэн та нарт Их Эзэн ийн хэлжээ—

9 Учир нь бие махбодийн дагуу та нар хууль ёсны “өв залгамжлагчид юм, мөн тэрхүү дэлхийгээс Христтэй хамт Бурхан дотор ^бнууцлагдсан билээ—

10 Тиймийн тул та нарын амьдрал хийгээд санваар үлдсэн байна, мөн дэлхий эхэлснээс хойш бүх ариун бошиглогчдын амаар хэлэгдсэн бүх зүйлийн “сэргээлт хүртэл та нар хийгээд та нарын удмаар дамжин үлдсэн байх ёстой нь шаардлагатай болой.

11 Тиймийн тул, хэрэв та нар миний сайн сайханд, харийнханд “гэрэл, мөн энэхүү санваараар дамжин миний хүмүүс ^бИзраилд аврагч байхаа үргэлжлүүлэх аваас, адислагдсан болой та нар. Их Эзэн үүнийг хэлэв. Амен.

ХЭСЭГ 87

1832 оны арванхоёрдугаар сарын 25-нд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн дайны тухай илчлэлт хийгээд бошиглол оршвой (History of the Church, 1:301–302). Америк тив дэх Африк хүмүүсийн боолчлол хийгээд дэлхий дээрх хүмүүний үрсийн боолчлолын талаар ах нар тунгаан бодож мөн хэлэлцэж байсан үед энэ хэсэг хүлээн авагджээ.

1–4, Умард муж улсууд хийгээд Өмнөд муж улсуудын хоорондын дайн угтан хэлэгдэв; 5–8, Агуу сүйрэл дэлхийн бүх оршин суугчид дээр буух болно.

ОЛОН бодгалийн үхэл хийгээд зовлонгоор эцэстээ дуусах “Өмнөд Каролины бослогоор эхлэн, удахгүй тохиох дайнуудын талаар

8а С ба Г 113:8.
су Мелкизедек санваар.

9а Абр. 2:9–11.
су Абрахамын

гэрээ.
б Иса. 49:2–3.
10а Үйлс 3:19–21.
су Сайн мэдээний сэргээлт.

11а Иса. 49:6.
б С ба Г 109:59–67.
87 1а С ба Г 130:12–13.

Их Эзэн ийн үнэнээр хэлж байна;

2 Мөн энэ газарт эхэлсэн “дайн бүх үндэстнүүд дээр юүлэгдэх тэр цаг ирэх болно.

3 Учрыг болгоогтун, Өмнөд муж улсууд Умард муж улсуудын эсрэг хуваагдах болно, мөн Өмнөд муж улсууд, бусад үндэстнүүдийг, бүр энэ нь нэрлэгддэгчлэн Их Британийг дуудах болно, мөн тэд өөрсдийгөө үндэстнүүдийн эсрэг хамгаалахын тулд бусад үндэстнүүдийг дуудах болно; мөн тэгээд “дайн бүх үндэстнүүд дээр тэрчлэн юүлэгдэх болно.

4 Мөнхүү улиран тохиох дор, олон өдрийн дараа дайны тулд дайчлагдан мөн сургуулилсан эздийнхээ эсрэг “боолчууд босох болно.

5 Мөнхүү улиран тохиох дор тэрчлэн уг нутагт үлдсэн тэрхүү үлдэгсэд өөрсдийгөө дайчлах болно, мөн үлэмж ихээр ууртай байх болно, мөн Харийнханд гашуун шаналал учруулах болно.

6 Мөн ийн илдээр мөн цус урсгалтаар дэлхийн оршин суугчид “гашуудах болно; дэлхийн оршин суугчид бүх үндэстнүүдийн бүрэн ⁶төгсгөлийг бий болгосон устгал тогтоогдох хүртэл ⁶өсгөлөнгөөр мөн тахал мөн газар хөдлөлт мөн тэнгэрийн аянга мөн тэрчлэн хурц хийгээд догшин гялбаагаар Бүхнийг Чадагч Бурханы гарын хилэгнэл мөн зэвүүцэл, мөн ⁷зэмлэлийг мэдрэхээр болгогдох болно;

7 Дайснуудаас нь өс авагдах гэгээнтнүүдийн хашгиралт мөн гэгээнтнүүдийн “цусных, газар дэлхийгээс ⁶Сабаотын Их Эзэний чихэнд ирэхээ болихын тулд болой.

8 Иймийн тул, ариун газруудад “зогсогтун та нар, мөн Их Эзэний өдөр ирэх хүртэл бүү шилжин нүүлгэгд; учрыг болгоогтун, энэ нь ⁶гэнэт ирэх болой хэмээн Их Эзэн хэлэв. Амен.

ХЭСЭГ 88

1832 оны арванхоёрдугаар сарын 27-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:302–312). Энэ бол Диваажингийн модноос таслан авсан “чидуны навч” лугаа адил бидэнд хүрч ирсэн Их Эзэний амар амгалангийн захиас хэмээн Бошиглогчоор тодорхойлогджээ. Энэхүү илчлэлтийн хэсгүүд түүхийн цэдгүүдийн дагуу

2a Иоел 3:9–16;
Мат. 24:6–7;
С ба Г 45:26, 63;
63:33.

3a С ба Г 45:68–69.

4a С ба Г 134:12.

6a С ба Г 29:14–21;

45:49.

б су Дэлхий—

Дэлхийн төгсгөл.

в ИС—А 1:29.

г су Зэмлэх, Зэмлэл.

7a Ифер 8:22–24.

б Иаков 5:4;

С ба Г 88:2; 95:7.

8a Мат. 24:15;

С ба Г 45:32;

101:21–22.

б Илч. 3:11.

1832 оны арванхоёрдугаар сарын 27, 28 түүнчлэн 1833 оны нэгдүгээр сарын 3-нд хүлээн авагдсан бололтой.

1-5, *Итгэлтэй Гэгээнтнүүд мөнх амьдралын амлалт болох Тайтгаруулагчийг хүлээн авдаг*; 6-13, *Бүх зүйл Христийн Гэрлээр хянагдаж мөн удирдагддаг авай*; 14-16, *Амилуулалт Гэтэлгэлээр дамжин ирдэг*; 17-31, *Селестиел, террестриел, эсвээс телестиел хуульд дуулгавартай байх нь хүмүүнийг тэдгээр тус тусын хаант улсууд хийгээд алдар суунуудад бэлтгэдэг*; 32-35, *Нүгэлд байх тэд бузар хэвээр үлддэг*; 36-41, *Бүх хаант улсууд хуулиар удирдагддаг ажгуу*; 42-45, *Бурхан бүх зүйлд хууль өгсөн билээ*; 46-50, *Хүмүүн бүр Бурханыг ойлгох болно*; 51-61, *Үйлчлэгчдээ талбайд илгээж мөн тэдэн дээр дараа нь очдог хүний тухай сургаалт зүйрлэл*; 62-73, *Их Эзэнд ойр байгтун, мөн та нар түүний нүүрийг харах болно*; 74-80, *Өөрсдийгөө ариусга мөн хаант улсын сургаалуудыг бие биендээ заагтун*; 81-85, *Сэрэмжлүүлэгдсэн хүн болгон хөршөө сэрэмжлүүлэх ёстой*; 86-94, *Тэмдгүүд, элементүүдийн хөдлөлт, мөн тэнгэр элчүүд Их Эзэний ирэлтийн тулд, замыг нь бэлтгэдэг болой*; 95-102, *Тэнгэр элчийн бүррэнүүд нас барагсдыг дарааллаар нь урагш дууддаг*; 103-116, *Тэнгэр элчийн бүррэнүүд сайн мэдээний сэргээлт, Вавилоны уналт, агуу их Бурханы тулалдааныг тун-*

хагладаг; 117-126, *Суралцахыг эрэлхийлэгтүн, Бурханы өргөө (ариун сүм) байгуул, мөн өөрсдийгөө энэрлийн холбоогоор хувцаслагтун*; 127-141, *Бошиглогчдын сургуулийн тогтсон журам түүний дотор хөл угаах ёслол толилуулагдав.*

ӨӨРСДИЙНХӨӨ талаарх түүний тааллыг хүлээн авахаар өөрсдийгөө цуглуулсан та нарт Их Эзэн үнэнээр, ийн хэлэв:

2 Болгоогтун, энэ нь та нарын Их Эзэнийг баярлуулж байна, мөн тэнгэр элчүүд та нарын улмаас “баясна; та нарын залбирлуудын “өргөл “Сабаотын Их Эзэний чихэнд ирж мөн ариусгагдсан тэдний, бүр селестиел дэлхийн тэдний нэрсийн ‘номонд цэдэглэгдсэн бөлгөө.

3 Иймийн тул, би эдүгээ та нарт, бүр найз нартаа, өөр нэгэн “Тайтгаруулагчийг, та нарын зүрх сэтгэлд оршиж болохын тулд бүр амлалтын “Ариун Сүнсийг илгээнэ; тэрхүү өөр Тайтгаруулагч нь Иоханы гэрчлэлд цэдэглэгдсэнчлэн, шавь нартаа миний амласан түүнтэй адил билээ.

4 Энэхүү Тайтгаруулагч бол та нарт миний өгч буй “мөнх амьдралын, бүр селестиел

88 2a Лук 15:10.
б Үйлс 10:1-4.
су Залбирал.
в Иаков 5:4;

С ба Г 95:7.
г су Амьдралын ном.
3a Иохан 14:16.
б С ба Г 76:53.

су Амлалтын
Ариун Сүнс.
4a С ба Г 14:7.

хаант улсын ^балдар суугийн амлалт юм;

5 Энэхүү алдар суу бол “Ууган Хүүгийн сүмийнх, бүр түүний Хүү Есүс Христээр дамжсан, бүхнээс хамгийн ариун Бурханы тэрхүү алдар суу юм —

6 “Тэрээр бүхэнд мөн бүх зүйлээр, үнэний ^бгэрэл байж болохын тулд Тэнгэрт дээш гарсан тэрээр мөн түүнээс гадна бүх зүйлийн доор ^ббууж ирснээр тэрбээр бүх зүйлийг ^бухамсарласан билээ;

7 Тэрхүү үнэн гэрэлтдэг. Энэ бол Христийн “гэрэл юм. Түүнээс гадна тэр наранд, мөн нарны гэрэл, мөн үүний хүч байдагчлан, үүгээр энэ нь ^бхийгдсэн болой;

8 Тэрчлэн тэрхүү саранд байдагчлан, мөн сарны гэрэл мөн үүний хүч бөлгөө, үүгээр энэ нь хийгдсэн болой;

9 Тэрчлэн оддын гэрэл мөн тэдгээрийн хүч байдагчлан, эдгээрээр тэдгээр нь хийгдсэн болой;

10 Мөн тэрчлэн дэлхий, бүр дээр нь та нарын “зогсдог дэлхий, мөн үүний хүч болой.

11 Мөн гэрэлтдэг, та нарт гэрэл өгдөг тэрхүү гэрэл нь та нарын мэлмийг гэгээрүүлдэг түүгээр дамжсан байдаг нь та нарын “ойлголтуудыг амьдруулдаг мөнхүү тэр гэрэл бөлгөө.

12 Уг “гэрэл нь сансрын хязгааргүй уудмыг ^бдүүргэхийн тулд Бурханы дэргэдээс урагш гардаг буюу.

13 Тэрхүү гэрэл “бүх зүйлд байдаг, бүх зүйлд ^бамьдралыг өгдөг, бүх зүйл түүгээр зохицуулагддаг “хууль болох, бүр үүрд мөнхийн цээжинд байдаг, бүх зүйлийн дунд буй, хаан сэнтийдээ залран суудаг Бурханы хүч буюу.

14 Эдүгээ, та нарын төлөө хийгдсэн “гэтэлгэлээр дамжин нас барагсдаас амилуулалт тохион авчрагддаг гэдгийг би үнэнээр та нарт хэлж байна.

15 Мөн “сүнс хийгээд мөн ^ббие нь хүмүүний ^ббодгаль бөлгөө.

16 Мөн нас барагсдын “амилуулалт нь бодгалийн гэтэлгэл болой.

17 Мөн бодгалийн гэтэлгэл

4б су Селестиел алдар суу.

5а су Ууган.

6а су Есүс Христ.

б С ба Г 93:2, 8–39.

су Гэрэл, Христийн гэрэл; Үнэн.

в С ба Г 122:8.

су Цагаатгах, Цагаатгал.

г су Бүхнийг Мэдэгч.

7а Моро. 7:15–19;

С ба Г 84:45.

б Эхл. 1:16.

су Бүтээх, Бүтээл.

10а Мосе 2:1.

11а су Мэдлэг.

12а су Гэрэл, Христийн гэрэл.

б Иер. 23:24.

13а Кол. 1:16–17.

б Дэд хууль 30:20;

С ба Г 10:70.

в Иов 38;

С ба Г 88:36–38.

су Хууль.

14а су Цагаатгах,

Цагаатгал;

Гэтэлгэлийн

төлөвлөгөө.

15а су Хүмүүн, Хүмүүс— Хүн,

Тэнгэрлэг Эцэгийн

сүнсэн хүүхдүүд;

Сүнс.

б су Бие.

в Эхл. 2:7. су Бие.

16а Алма 11:42.

су Амилуулалт.

нь “дэлхийн ^бядуус хийгээд “доройчууд үүнийг өвлөх болно хэмээн цээжинд нь тогтоогддог бүх зүйлийг амьдруулдаг түүгээр дамжадаг бөлгөө.

18 Тиймийн тул, энэ нь “селестиел алдар суугийн тулд бэлтгэгдэж болохын тулд энэ нь бүхий л шударга бусаас ариусгагдах ёстой нь шаардлагатай бөлгөө;

19 Учир нь бүтээлтийн хэмжүүрээр энэ нь дүүрсний дараа, энэ нь “алдар суугаар, бүр Бурхан Эцэгийн оршихуйгаар титэмлэгдэх болно;

20 Селестиел хаант улсынх болох тэдгээр биес үүнийг үүрд мөн мөнхөд “эзэмшиж болохын тулд буюу; учир нь энэхүү ^бзорилгын улмаас, энэ нь хийгдсэн мөн бүтээгдсэн юм, мөн энэхүү зорилгын улмаас, тэд “ариусгагдсан бөлгөө.

21 Мөн та нарт миний өгсөн хуулиар, бүр Христийн хуулиар дамжин ариусгадаггүй тэд өөр хаант улсыг, бүр террестриел хаант улсыг, эсвээс телестиел хаант улсыг өвлөх ёстой.

22 Учир нь селестиел хаант

улсын “хуулийг мөрдөх боломжгүй тэд селестиел алдар сууг тэсэн гарч чадахгүй.

23 Мөн террестриел хаант улсын хуулийг мөрдөж чаддаггүй тэд “террестриел алдар сууг тэсэн гарч чадахгүй.

24 Мөн телестиел хаант улсын хуулийг мөрдөж чаддаггүй тэд “телестиел алдар сууг тэсэн гарч чадахгүй; тиймийн тул, тэрээр алдар суугийн хаант улсад үл тохирох авай. Тиймийн тул, тэрээр алдар суугийн хаант улс бус хаант улсыг тэсэн гарах ёстой.

25 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, “газар дэлхий селестиел хаант улсын хуулийг мөрддөг бөлгөө, учир нь энэ нь бүтээлтийнхээ хэмжүүрийг дүүргэдэг мөн хуулийг зөрчдөггүй—

26 Иймийн тул, энэ нь “ариусгагдах болно; тийм ээ, хэдийгээр энэ нь ^бүхэх боловч, энэ нь дахин амьдруулагдах болно, мөн амьдруулагдсан тэрхүү хүчийг тэсэн гарах болно, мөн “зөв шударга хүмүүс үүнийг ‘өвлөх болно.

27 Учир нь хэдийгээр тэд нас нөгчих хэдий ч, тэд тэрчлэн

17a су Дэлхий—
Дэлхийн эцсийн байдал.
б су Ядуу.
в су Номхон дөлгөөн, Номхон дөлгөөн байдал.
18a су Селестиел алдар суу.
19a С ба Г 130:7–9.
20a С ба Г 38:20.

б Моце 1:39.
су Хүмүүн, Хүмүүс—
Хүн, Тэнгэрлэг Эцэгтэй адил болох боломж.
в су Ариусгал.
22a С ба Г 105:5.
23a су Террестриел алдар суу.
24a су Тэлэстиел алдар суу.

25a су Газар дэлхий.
26a су Дэлхий—Дэлхийн эцсийн байдал.
б су Дэлхий—
Дэлхийн төгсгөл.
в 2 Петр 3:11–14.
су Зөв шударга, Зөв шударга ёс.
г Мат. 5:5;
С ба Г 45:58; 59:2; 63:49.

“сүнстэй бие болон дахин
босч ирэх болно.

28 Селестиел сүнснийх болох
тэд ердийн биетэйгээ яг адил
тийм биеийг хүлээн авах
болно; мөн та нар өөрсдийн-
хөө биеийг хүлээн авах болно,
мөн та нарын “алдар суу та
нарын биенд амьдруулагдах
тийм алдар суу байх болно.

29 “Селестиел алдар суу-
гийн хувь хэмжээгээр амьд-
руулагддаг та нар тэгээд
үүнийг, бүр бүрэн байдлаар
нь хүлээн авах болно.

30 Мөн “террестриел алдар
суугийн хувь хэмжээгээр
амьдруулагддаг тэд дараа нь
мөн үүнийг, бүр бүрэн байд-
лаар нь хүлээн авах болно.

31 Мөн тэрчлэн “телестиел
алдар суугийн хувь хэмжээ-
гээр амьдруулагдах тэд да-
раа нь мөн үүнийхийг, бүр
бүрэн байдлаар нь хүлээн
авах болно.

32 Мөн үлдсэн тэд тэрчлэн
“амьдруулагдах болно; гэсэн
хэдий ч, тэд хүлээн авахад
бэлэн байгаа түүнийгээ эд-
лэхийн тулд байрандаа дахин
буцаж очих болно, учир нь
тэд хүлээн авч болох байсан
үүнийг эдлэхийн тулд тэд
бэлэн байгаагүй ажээ.

33 Учир нь хэрэв түүнд

бэлэг хүртээгдсэн байхад мөн
тэрээр уг бэлгийг хүлээн
аваагүй бол энэ нь хүмүүнд
ямар ашиг тус авчрах билээ;
Болгоогтун, тэрээр өөрт нь
өгөгдсөн тэр зүйлд баясах нь
үгүй, мөн уг бэлгийг өгөгч
болох түүнд ч баясах нь үгүй
болой.

34 Мөн дахин, үнэнээр би та
нарт хэлж байна, хуулиар зо-
хицуулагддаг тэр нь тэрчлэн
хуулиар хамгаалагдан мөн
төгөлдөржиж мөн түүгээр
“ариусгагддаг бөлгөө.

35 Хууль “зөрчигч, мөн хуу-
лийг мөрддөггүй атлаа өөрөө
өөртөө хууль бий болгохыг
эрэлхийлдэг, мөн нүгэлд
байхыг хүсдэг, мөн бүхэлдээ
нүгэлд байдаг тэр нь хуулиар
ч, мөн нигүүлслээр ч, “шу-
дарга ёсоор ч, мөн шүүлтээр
ч ариусгагдаж чадах нь үгүй.
Тиймийн тул, тэд “бузар
хэвээр үлдэх ёстой.

36 Бүх хаант улс өгөгдсөн
хуультай болой;

37 Мөн олон “хаант улс буй;
учир нь хаант улс үл байх
орон зай гэж үгүй; мөн илүү
агуу эсвээс доод хаант улс гэж
байхаас, орон зайд үл байх
хаант улс гэж үгүй бөлгөө.

38 Мөн хаант улс болгонд
“хууль өгөгдсөн болой; мөн

27a 1 Кор. 15:44.

б су Амилуулалт.

28a су Эцсийн шүүлт.

б С ба Г 43:32; 63:51;
101:31.

29a су Селестиел
алдар суу.

б су Хүмүүн,
Хүмүүс—Хүн,
Тэнгэрлэг Эцэгтэй

адил болох
боломж.

30a су Террестриел
алдар суу.

31a су Телестиел
алдар суу.

32a Алма 11:41–45.

б су Сонгох эрх.

34a су Ариусгал.

35a су Эсэргүүцэл.

б су Нигүүлсэнгүй,
Нигүүлсэл.

в су Шударга ёс.

г Илч. 22:11;

1 Ниф. 15:33–35;

2 Ниф. 9:16;

Алма 7:21.

37a С ба Г 78:15.

38a С ба Г 88:13.

хууль болгонд тодорхой хязгаарууд тэрчлэн мөн нөхцөлүүд буй.

39 Тэдгээр “нөхцөлүүдийг мөрддөггүй бүх хүмүүн” зөвтгөгддөггүй бөлгөө.

40 Учир нь “оюун билиг оюун билигтэй нэгдэн нийлдэг;”⁶ мэргэн ухаан мэргэн ухааныг хүлээж авдаг; “үнэн нь үнэнийг тэврэн авдаг;” ариун журам ариун журмаа хайрладаг;⁷ гэрэл гэрэлтэй нэгдэн нийлдэг, нигүүлсэл нь нигүүлслийн “өрөвч сэтгэлийг агуулж, мөн өөрийнхөндөө үзүүлдэг; шударга ёс өөрийнхөө замыг үргэлжлүүлж мөн өөрийнхөөсөө шаарддаг; мөн хаан сэнтий дээр заларч мөн зохицуулдаг мөн бүх зүйлийг гүйцэтгэдэг түүний нүүрний өмнө шүүлт явдаг билээ.

41 Тэрээр бүх зүйлийг “ухамсарладаг, мөн бүх зүйл түүний өмнө байдаг, мөн бүх зүйл түүний эргэн тойронд байдаг, мөн тэрбээр бүх зүйлийн дээгүүр, мөн бүх зүйлд байдаг, мөн бүх зүйлээр дамжсан байдаг, мөн бүх зүйлийн эргэн тойронд байдаг; мөн бүх зүйл түүгээр, мөн түүнээс, бүр Бурханаас, үүрд мөн мөнхөд болой.

42 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, тэрээр бүх

зүйлд хууль өгсөн билээ, үүгээр тэд өөрсдийнхөө “цагт хийгээд өөрсдийнхөө улирлуудад хөдөлдөг бөлгөө;

43 Мөн тэдний замналууд дэлхий болон бүх гаригийг багтаадаг, бүр тэнгэрийн хийгээд дэлхийн тэрхүү замналууд тогтоогдсон болой.

44 Мөн тэд өөрсдийнхөө хормуудад, мөн өөрсдийнхөө цагт, мөн өөрсдийнхөө улирлуудад, өөрсдийнхөө өдрүүдэд, мөн өөрсдийнхөө долоо хоногуудад, өөрсдийнхөө саруудад, мөн өөрсдийнхөө жилүүдэд бие биендээ “гэрэл өгдөг — эдгээр бүгд нь хүмүүний хувьд бус, харин Бурханы хувьд”⁶ нэг жил билээ.

45 Дэлхий далавчнууд дээрээ эргэлдэж, мөн “нар гэрлээ өдрөөр өгдөг, мөн сар гэрлээ шөнөөр өгдөг, мөн одод, тэдгээр нь өргөмжлөлийн түвшинд далавчнууд дээрээ эргэлдэх үед Бурханы “хүчин дотор тэрчлэн гэрлээ өгдөг авай.

46 Та нар ойлгож болохын тулд эдгээр хаант улсуудыг бибээр юутай адилтгах билээ?

47 Болгоогтун, эдгээр бүгд нь хаант улсууд болой, мөн эдгээрийн хамгийн доод алиныг нь ч харсан аль ч хүмүүн сүр жавхлан хийгээд

39a С ба Г 130:20–21.

б су Зөвтгөл,

Зөвтгөх.

40a су Оюуны өндөр хөгжил.

б су Мэргэн ухаан.

в су Үнэн.

г су Нөлөөлөх хүч.

д су Гэрэл, Христийн гэрэл.

е су Өрөвч сэтгэл.

41a 1 Иохан 3:20;

1 Ниф. 9:6;

2 Ниф. 9:20;

С ба Г 38:1–3.

су Бүхнийг Мэдэгч.

42a Дан. 2:20–22;

Абр. 3:4–19.

44a су Гэрэл, Христийн гэрэл.

б Дуул. 90:4;

2 Петр 3:8.

45a Эхл. 1:16; Абр. 4:16.

б С ба Г 88:7–13.

сүр хүчиндээ хөдлөн яваа Бурханыг “харсан бөлгөө.

48 Би та нарт хэлж байна, тэрээр түүнийг харсан билээ, гэсэн хэдий ч, “өөрсдийнхөндөө ирсэн тэрээр хүлээн зөвшөөрөгдөөгүй билээ.

49 “Гэрэл нь харанхуйд гэрэлтдэг, мөн харанхуй нь үүнийг ойлгох нь үгүй; гэсэн хэдий ч, түүнд мөн түүгээр амьдруулагдсан учраас та нар бүр Бурханыг “ойлгох өдөр ирэх болно.

50 Тэгээд та нар намайг харсан гэдгээ, би байдаг гэдгийг, мөн би бол та нарт буй тэрхүү үнэн гэрэл гэдгийг, мөн та нар надад байдаг гэдгийг та нар мэдэх болно; эс тэгвээс та нар өсөн хөгжиж чадах нь үгүй.

51 Болгоогтун, эдгээр хаант улсуудыг би талбайтай хүнтэй адилтгах болно, мөн тэрээр зарц нараа талбайд газар ухуулахаар талбай уруу урагш илгээжээ.

52 Мөн тэрээр эхнийхэд хэлэв: Чи явж мөн талбайд хөдөлмөрлөгтүн, мөн эхний цагт бибээр та нар дээр очих болно, мөн чи миний баяр хөөртэй дүр төрхийг болгоох болно.

53 Мөн тэрээр хоёр дахид нь хэлэв: Чи тэрчлэн талбай уруу явагтун, мөн хоёрдахь цагт бибээр баяр хөөртэй дүр төрхөөрөө чам дээр зочлох болно.

54 Мөн тэрчлэн гурав дахид нь хэлэв: Бибээр чам дээр зочлох болно;

55 Мөн дөрөв дэхэд нь, мөн энэчлэнгээр цааш нь арван хоёрдахид нь буюу.

56 Мөн талбайн эзэн эхнийх уруу эхний цагт очиж, тэрхүү бүх цагт түүнтэй хамт үлдэв, мөн эзнийхээ дүр төрхний гэрлээр тэрээр баяртай болгогдсон байв.

57 Мөн тэгээд хоёрдахид тэрчлэн дөрөвдэхэд мөн энэ мэтчилэнгээр цааш арванхоёр дахид айлчилж болохын тулд тэрээр эхнийхээс явав.

58 Мөн ийн тэд бүгдээр хүн болгон өөрийнхөө цагт мөн өөрийнхөө хугацаанд мөн өөрийнхөө улиралд эзнийхээ дүр төрхний гэрлийг хүлээж авсан ажгуу —

59 Нэгдэхэд эхлэн, мөн энэчлэнгээр цааш “сүүлчийнхэд нь мөн сүүлчийнхээс эхнийхэд нь мөн эхнийхээс сүүлчийнхэд нь буюу;

60 Эзэн нь түүнд мөн тэрээр өөрийнхөө эзэнд алдаршиж болохын тулд, тэд бүгд алдаршиж болохын тулд хүн болгон өөрийнх нь цаг дууссан байх хүртэл, бүр түүний эзэн өөрт нь зарлигласны дагуу өөрийнхөө дараалалд буюу.

61 Тиймийн тул, би эдгээр бүх хаант улсыг мөн тэдгээрийн “оршин суугчдыг — хаант улс бүрийг үүний цагт нь, мөн үүний хугацаанд нь,

47a Алма 30:44;
Моце 1:27–28; 6:63;
Абр. 3:21.
48a Иохан 1:11;

3 Ниф. 9:16;
С ба Г 39:1–4.
49a С ба Г 6:21; 50:23–24;
84:45–47.

б Иохан 17:3;
С ба Г 93:1, 28.
59a Мат. 20:1–16.
61a С ба Г 76:24.

мөн үүний улиралд нь, бүр Бурханы хийсэн тэрхүү тогтоолын дагуу, энэхүү сургаалт зүйрлэлтэй адилтгах болно.

62 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, “найз нар минь, та нар намайг ойр байхад намайг ^бдуудаж болохын тулд эдгээр айлдваруудыг та нарт миний өгсөн энэхүү зарлигийн хамт та нар зүрх сэтгэлдээ “тунгаан бодохын тулд би та нарт үлдээе —

63 Надад “ойр байгтун, мөн би та нарт ойр байх болно; намайг хичээнгүйлэн ^бэрэлхийлэгтүн, мөн та нар намайг ^оолох болно; асуу тэгвэл та нар хүлээн авах болно; тогш, тэгвэл энэ нь та нарт нээгдэх болно.

64 Миний нэрээр та нар Эцэгээс юу ч ^агуйлаа гэсэн, өөрсдөд чинь ^бшаардлагатай тэр нь та нарт өгөгдөх болно;

65 Мөн хэрэв та нар өөрсдөдөө ^ашаардлагагүй ямар нэг зүйлийг гуйваас, энэ нь та нарт ^ббуруушаалт болон хувирах болно.

66 Болгоогтун, та нарын сонсож буй тэр бол аглаг буйдад хашгирах нэгний ^адуу хоолой мэт бөлгөө — учир юун гэвэл

та нар түүнийг харж чадахгүй — миний дуу хоолой, учир юун гэвэл миний дуу хоолой бол ^бСүнс мөн; миний Сүнс бол үнэн билээ; “үнэн үргэлж оршдог бөгөөд төгсгөл гэж үгүй; хэрэв энэ нь та нарт байх аваас, энэ нь өсөлт хөгжилт байх болно.

67 Мөн хэрэв та нар миний “сүр жавхлангийн төлөө ^ббүхнээ зориулах аваас, та нарын бүхэл бие гэрлээр дүүргэгдэх болно, мөн та нарт харанхуй байх нь үгүй; мөн гэрлээр дүүргэгдсэн тэрхүү бие бүх зүйлийг ^аухамсарладаг бөлгөө.

68 Тиймийн тул, та нарын “оюун Бурханд бүхлээрээ зориулагддаг болохын тулд өөрсдийгөө ^бариусга, мөн та нар түүнийг ^ахарах тэрхүү өдрүүд ирэх болно; учир нь тэрээр нүүрээ та нарт харуулах болно, мөн энэ нь түүний өөрийнх нь цагт, мөн түүний өөрийнх нь замаар, мөн түүний өөрийнх нь тааллын дагуу байх болно.

69 Та нарт миний өгсөн агуу хийгээд сүүлчийн амлалтыг санагтун; өөрсдийнхөө дэмий “хоосон бодол санаа хийгээд

62a С ба Г 84:63; 93:45.

б Иса. 55:6;

Иаков 1:5;

С ба Г 46:7.

в су Тунгаан бодох.

63a Зех. 1:3; Иаков 4:8;

Илч. 3:20.

б Шаст. дээд 28:9;

Ифер 12:41;

С ба Г 101:38.

в С ба Г 4:7; 49:26.

64a су Залбирал.

б С ба Г 18:18; 46:28–30.

65a Иаков 4:3.

б С ба Г 63:7–11.

66a Иса. 40:3;

1 Ниф. 17:13;

Алма 5:37–38;

С ба Г 128:20.

б су Ариун Сүнс;

Гэрэл, Христийн

гэрэл.

в су Үнэн.

67a Иохан 7:18.

б Мат. 6:22;

Лук 11:34–36;

С ба Г 82:19.

в Сур. үгс 28:5;

С ба Г 93:28.

су Ялган таних

бэлэг.

68a су Оюун.

б су Ариусгал.

в С ба Г 67:10–13;

93:1; 97:15–17.

69a Мат. 12:36;

Мозая 4:29–30;

Алма 12:14.

илүүц чанга ^бинээдээ өөрсдөөсөө хол хая.

70 Үлдэгтүн та нар, энэхүү газарт үлд та нар, мөн онцгой ариун хуралдайг, бүр энэхүү сүүлчийн хаант улсад анхлан хөдөлмөрлөгч тэднийхийг зарлан хуралдуул.

71 Аялалдаа ^асэрэмжлүүлсэн тэд Их Эзэнийг дуудаг, мөн хүлээн авсан сэрэмжлүүлгээ зүрх сэтгэлдээ богинохон хугацаанд тунгаан бодог.

72 Болгоогтун, мөн харагтун, та нарын сүргийн төлөө бибээр анхаарал халамж тавих болно, мөн ахлагчдыг бэлтгэж мөн тэдэнд илгээх болно.

73 Болгоогтун, бибээр өөрийн ажлыг зохих цагт нь яравчлуулах болно.

74 Мөн та нар өөрсдийгөө хамтад нь цуглуул, мөн өөрсдийгөө зохион байгуул, мөн өөрсдийгөө бэлтгэ, мөн өөрсдийгөө ^аариусга хэмээх зарлигийг энэхүү эцсийн хаант улсын анхны ^бхөдөлмөрлөгчид болох та нарт би өгч байна; тийм ээ, би та нарыг ^сцэвэр ариун болгож болохын тулд зүрх сэтгэлээ цэвэршүүл, мөн миний өмнө гараа мөн хөлөө ^дцэвэршүүлэгтүн;

75 Та нарын ^аЭцэг, мөн та нарын Бурхан, мөн миний

Бурханд бибээр гэрчилж болохын тулд, та нар ёс бус энэ үеийнхний цуснаас цэвэр ариун бай; энэхүү амлалтыг та нарт миний хийсэн энэхүү агуу хийгээд сүүлчийн амлалтыг хүсэх үедээ бибээр биелүүлж болохын тулд буюу.

76 Тэрчлэн та нар энэ цагаас хойш ^азалбирал хийгээд ^бмацгаа үргэлжлүүлэх болно хэмээх зарлигийг би та нарт өгч байна.

77 Мөн хаант улсын ^асургаалыг та нар бие биендээ ^бзаах болно хэмээх зарлигийг би та нарт өгч байна.

78 Та нар онолд, зарчимд, номлолд, сайн мэдээний хуулинд, та нарын ойлголтод шаардлагатай Бурханы хаант улсад хамаардаг бүх зүйл илүү төгс ^азааварлагдаж болохын тулд хичээнгүйлэн заагтун та нар, мөн миний ^бач ивээл та нартай байх болно;

79 ^аТэнгэр дэх мөн дэлхий дэх мөн дэлхийн доорх зүйлүүдийн тухай; байсаар ирсэн зүйлүүд, байгаа зүйлүүд, удахгүй тохиох зүйлүүд; гэрт байгаа зүйлүүд, хол байгаа зүйлүүд; ^бдайнуд болон үндэстнүүдийн ээдрээтэй байдал, мөн уг нутаг дээрх шүүлтүүд; мөн тэрчлэн улс

69б С ба Г 59:15; 88:121.

71а су Сэрэмжлэх, Сэрэмжлүүлэг.

74а Лев. 20:7–8;

3 Ниф. 19:28–29;

С ба Г 50:28–29;

133:62.

б Мат. 20:1, 16.

в су Цэвэр ба Цэвэр бус явдал.

г Ифер 12:37.

75а су Бурхан, Бурхан тэргүүтэн — Эцэг Бурхан; Тэнгэр дэх Эцэг; Хүмүүн, Хүмүүс—Хүн, Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүд.

76а су Залбирал.

б су Мацаг барих,

Мацаг барилт.

77а су Христийн сургаал.

б су Заах, Багш.

78а С ба Г 88:118;

90:15; 93:53.

б су Ач ивээл.

79а су Тэнгэр.

б су Дайн.

орнуудын тухай хийгээд хаант улсуудын тухай мэдлэг буюу —

80 Та нарыг бибээр дуудсан тэрхүү дуудлагыг, би та нарт итгэмжилсэн тэрхүү үүрэг даалгаврыг хичээнгүйлэн гүйцэтгүүлэхээр би та нарыг дахин илгээхэд та нар бүх зүйлд бэлтгэгдэж болохын тулд буюу.

81 Болгоогтун, хүмүүст “гэрчлэх хийгээд сэрэмжлүүлэхээр би та нарыг илгээсэн билээ, мөн сэрэмжлүүлэгдсэн хүн болгон хөршөө ^бсэрэмжлүүлэх нь хэрэгтэй болой.

82 Тиймийн тул, тэд зөвтгөх шалтаггүйгээр үлдэх болно, мөн тэдний нүглүүд өөрсдийнх нь толгой дээр буй.

83 Намайг “шамдан ^бэрэлхийлэх тэрээр намайг олох болно, мөн орхигдох нь үгүй.

84 Тиймийн тул, үлдэгтүн та нар, мөн та нар Их Эзэний ам нэрлэх болгон нь сүүлчийн удаа “харийнханы дунд урагш одон хуулийг ^ббитүүмжлэн мөн гэрчлэлийг лацдаж, мөн тохиох гэж буй шүүлтийн цагт гэгээнтнүүдийг бэлтгэх тохинуулалдаа төгөлдөржиж болохын тулд хичээнгүйлэн хөдөлмөрлө.

85 Тэдний бодгалиуд Бурханы хилэгнэлээс, ёс бусчуудыг энэ дэлхий аль алинд нь хүлээж буй жигшүүрт хэргийн “эзгүйрлээс зайлж болохын тулд буюу. Үнэнээр би та нарт хэлнэ, Их Эзэний ам тэднийг ^бдуудтал анхдагч ахлагчид биш тэд талбайд үргэлжлүүлэг, учир нь тэдний цаг хараахан ирээгүй байна; тэдний өмсгөлүүд энэ үеийнхний цуснаас ^бцэвэрлэгдээгүй байна.

86 Та нарыг “чөлөөтэй болгосон тэрхүү ^бэрх чөлөөндөө оршигтун та нар; өөрсдийгөө “нүгэлд бүү ‘орооцолдуул, харин Их Эзэнийг ирэх хүртэл та нарын гар ^бцэвэр байг.

87 Учир нь үүнээс олон бус өдрийн дараа мөн “дэлхий ^бчичирч мөн согтуу хүн лугаа адил ийш тийш ганхах болно; мөн “нар нүүрээ нуух болно, мөн гэрэл өгөхөөс татгалзах болно; мөн сар ‘цусанд хөвөх болно; мөн ^бодод үлэмж их уурлах болно, мөн инжрийн модноос унах инжир лугаа адил өөрсдийгөө доош шидэх болно.

88 Мөн та нарын гэрчлэлийн дараа хилэгнэл хийгээд

81a су Гэрчлэх.

б С ба Г 63:58.

су Сэрэмжлэх,

Сэрэмжлүүлэг.

83a Алма 37:35.

б Дэд хууль 4:29–31;

Иер. 29:12–14;

С ба Г 54:10.

84a ИС—Т 1:41.

б Иса. 8:16–17.

85a Мат. 24:15.

б С ба Г 11:15.

в 1 Ниф. 12:10–11;

Иаков 1:19; 2:2;

С ба Г 112:33.

су Цэвэр ариун,

Цэвэр ариун

байдал.

86a Иохан 8:36.

су Сонгох эрх; Эрх

чөлөө, Эрх чөлөөт

байдал.

б Мозая 5:8.

су Эрх чөлөө.

в су Нүгэл.

г Гал. 5:1.

д Иов 17:9;

Дуул. 24:4;

Алма 5:19.

87a Иса. 13:4–13.

б С ба Г 43:18.

в Иоел 2:10;

С ба Г 45:42; 133:49.

г Илч. 6:12.

д Иоел 3:15.

зэвүүцэл хүмүүс дээр ирэх бөлгөө.

89 Учир нь та нарын гэрчлэлийн дараа үүний дотор ёололт бий болгох “газар хөдлөлтүүдийн гэрчлэл ирэх болой, мөн хүмүүн газарт унаж мөн зогсч чадахгүй байх болно.

90 Мөн тэрчлэн аянгын “дуу хоолойны, мөн гялбааны дуу хоолойны, мөн шуургануудын дуу хоолойны, мөн өөрсдийгөө зааг хязгаараасаа халин шидлэх далайн давалгааны дуу хоолойны гэрчлэл ирэх бөлгөө.

91 Мөн бүх зүйл “үймээнд байх болно; мөн хүмүүний зүрх сэтгэл мохох нь гарцаагүй болно; учир нь бүх хүмүүс дээр айдас ирэх болно.

92 Мөн “тэнгэр элчүүд чанга дуу хоолойгоор хашгиран, Бурханы бүрээг дуугаргаж: Бэлтгэгтүн та нар, бэлтгэгтүн та нар, Ай дэлхийн оршин суугчид аа, учир нь бидний Бурханы шүүлт ирчихээд байна. Болгоогтун, мөн харагтун, ⁶Хүргэн Хүү ирж явна; түүнийг угтахаар гарагтун та нар хэмээн хэлж, тэнгэрийн дундуур сүлжин нисэх болно.

93 Мөн тэр даруй тэнгэрт “агуу тэмдэг гарч ирэх бол-

но, мөн бүх хүмүүс үүнийг хамтдаа харах болно.

94 Мөн өөр нэг тэнгэр элч: Тэр “агуу ⁶сүм, жигшүүрт хэргүүдийн ⁶эх, бүх үндэстнийг ⁶завхайрлынхаа хилэгнэлийн дарснаас уух болгосон, Бурханы гэгээнтнүүдийг мөшгин хавчдаг, их уснууд дээр, мөн далайн арлууд дээр суудаг тэрээр—болгоогтун, тэрээр дэлхийн ⁶зэрлэг өвс бөлгөө; тэрээр боодлуудад боогдсон буюу; түүний хүлээс хүчтэй болгогдсон болой, хүмүүн үүнийг суллаж чадах нь үгүй; тиймийн тул, тэрээр ⁶шатаагдахад бэлэн байна хэмээн хэлж бүрээгээ дуугаргах болно. Мөн тэрээр бүрээгээ удаан хийгээд чанга аль алинаар нь дуугаргах болно, мөн бүх үндэстэн үүнийг сонсох болно.

95 Мөн хагас цагийн хугацаанд тэнгэрт “нам гүм байх болно; мөн үүний дараа тэр даруй ⁶хуйлмал ном хуйлагдсаны дараа дэлгэгдэх лугаа адил тэнгэрийн хөшиг нээгдэх болно, мөн Их Эзэний “нүүр харагдах болно;

96 Мөн дэлхий дээрх гэгээнтнүүд амьд байгаа нь шинэчлэгдэж мөн түүнийг угтахаар дээш “аваачигдах болно.

89a С ба Г 45:33.

90a Илч. 8:5;

С ба Г 43:17–25.

91a С ба Г 45:26.

92a Илч. 8:13;

С ба Г 133:17.

б Мат. 25:1–13;

С ба Г 33:17;

133:10, 19.

93a Мат. 24:30;

Лук 21:25–27.

су Цаг хугацааны

тэмдгүүд.

94a 1 Ниф. 13:4–9.

б су Чөтгөр—

Чөтгөрийн сүм.

в Илч. 17:5.

г Илч. 14:8.

д Мат. 13:38.

е С ба Г 64:23–24;

101:23–25.

су Дэлхий—

Дэлхийн

цэвэршилт.

95a С ба Г 38:12.

б Илч. 6:14.

в су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

96a 1 Тес. 4:16–17.

97 Мөн булшиндаа нойрсон тэд урагш “гарч ирэх болно, учир нь тэдний булшнууд нээгдэх болно; мөн тэрчлэн тэд тэнгэрийн баганан дотор түүнийг угтахаар дээш аваачигдах болно —

98 Тэд бол Христийнх, “анхны үр жимснүүд бөлгөө, тэд бол түүнтэй хамт анх бууж ирэх тэд болой, мөн тэд бол дэлхий дээр байгаа, мөн түүнийг угтахаар анх түрүүн дээш аваачигдах, булшиндаа байгаа тэд бөлгөө; мөн энэ бүхэн Бурханы тэнгэр элчийн бүрэн дууны дуу хоолойгоор болой.

99 Мөн үүний дараа өөр нэг тэнгэр элч, хоёр дахь нь болох бүрээг дуугаргах болно; мөн тэгэхэд Христийнх болох тэдний, сайн мэдээг хүлээн авч мөн маханбодь дахь хүмүүний дагуу “шүүгдэж болохын тулд тэдэнд зориулж бэлтгэгдсэн тэрхүү ^бшоронд өөрсдийнхөө хувийг хүлээн авсан тэдний гэтэлгэл түүний ирэлтээр тохиох болой.

100 Мөн дахин, гурав дахь нь болох өөр нэг бүрээ дуугарах болно; мөн тэгэхэд шүүгдэх ёстой мөн “буруушаалт дор олдсон хүмүүсийн ^бсүнснүүд ирэх бөлгөө.

101 Мөн эд бол “нас барагсдын үлдсэн нь юм; мөн тэд дахин ^бмянган жил өнгөртөл бас дахин дэлхийн төгсгөл хүртэл амьдрах нь үгүй.

102 Мөн дөрөв дэх бүрээ болох өөр нэг бүрээ: Тэрхүү агуу хийгээд сүүлчийн өдөр, бүр төгсгөлийг хүртэл үлдэх ёстой тэдний дунд “бузар хэвээр үлдэх тэд болой хэмээн өгүүлж, дуугарах болно.

103 Мөн тав дахь бүрээ болох тав дахь тэнгэр элч өөр нэг бүрээ “үүрдийн сайн мэдээг бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүст итгэмжлэн тэнгэрийн дундуур сүлжин нисч, дуугарах болно.

104 Мөн энэ бол тэнгэр хийгээд дэлхий аль алин дахь мөн дэлхийн доорх бүх хүмүүст, Бурханаас “эмээгтүн, мөн хаан сэнтий дээрээ залрах түүнийг үүрд мөн мөнхөд магтан дуулагтун хэмээн хэлэх бүрэн дууг тэд сонсоод—^бчих бүхэн үүнийг сонсож, мөн өвдөг бүхэн ^всөхөрч, мөн хэл бүхэн хүлээн зөвшөөрөх болно, учир нь түүний шүүлтийн цаг ирчихээд байна хэмээн хэлэх ажгуу.

105 Мөн дахин, зургаа дахь тэнгэр элч болох өөр нэг тэнгэр элч бүрээгээ дуугарган

97a С ба Г 29:13;
45:45–46; 133:56.
су Амилууалт.

98a 1 Кор. 15:23.

99a 1 Петр 4:6.

б С ба Г 76:73; 138:8.
су Нас барагсдын
аврал.

100a су Яллах, Ял.

б Илч. 20:12–13;

Алма 11:41;

С ба Г 43:18; 76:85.

101a Илч. 20:5.

б су Мянган жил.

102a су Бузар, Бузар
явдал.

103a Илч. 14:6–7.

су Сайн мэдээний

сэргээлт.

104a су Айх, эмээх—
Бурханаас эмээх;
Хүндэтгэл.

б Илч. 5:13.

в Иса. 45:23;

Филип. 2:9–11.

өгүүлэх нь: Тэр бол бүх үндэстнийг өөрийн завхайрлын хилэгнэлийн дарснаас уух болгосон, “унасан тэрээр болой; тэр унасан, унасан!

106 Мөн дахин, долоо дахь тэнгэр элч болох өөр нэг тэнгэр элч бүрээгээ дуугарган өгүүлэх нь: Энэ нь дууслаа; энэ нь дууслаа! Бурханы “Хурга ^бдийлж, мөн дарсны шахуургыг, бүр Бүхнийг Чадагч Бурханы догшин хилэгнэлийн дарсны шахуургыг ганцаараа ^гтишгэлээ.

107 Мөн тэгээд тэнгэр элчүүд түүний хүчний алдар суугийн титмээр титэмлэгдэх болно, мөн “гэгээнтнүүд түүний ^балдар суугаар дүүргэгдэх болно, мөн өөрсдийн ^вөвийг хүлээн авч түүнтэй ^гадил тэгш болгогдох болно.

108 Мөн тэгээд нэг дэх тэнгэр элч амьд бүхний чихэнд бүрээгээ дахин дуугарган, мөн “эхний мянган жил дэх хүмүүний нууц үйлүүд мөн Бурханы хүчирхэг ажлуудыг ^билчлэх болно.

109 Мөн тэгээд хоёр дахь тэнгэр элч бүрээгээ дуугарган мөн хоёр дахь мянган жил дэх хүмүүний нууц үйлүүд мөн тэдний зүрх сэтгэлийн бодлууд хийгээд эрмэлзлэлүүд, мөн Бурханы

хүчирхэг ажлуудыг илчлэх болно.

110 Мөн энэчлэнгээр долоо дахь тэнгэр элч хүртэл бүрээгээ дуугаргах болно; мөн тэрээр газар дээр, мөн далай дээр урагш гаран зогсож, мөн хаан сэнтийд залрах түүний нэрээр, тэрхүү “цаг үргэлжлэхгүй байх болно хэмээн тангараглах болно; мөн чөтгөр хэмээн нэрлэгддэг, хөгшин хорт могой, “Сатан хүлэгдэх болно, мөн “мянган жилийн хугацаанд суллагдах нь үгүй.

111 Мөн тэгээд тэр өөрийн их цэргийг хамтад нь цуглуулж болохын тулд тэрээр багахан хугацаанд “суллагдах болно.

112 Мөн долоо дахь тэнгэр элч бүр тэргүүн тэнгэр элч “Михаил өөрийн их цэргийг, бүр тэнгэрийн түмнийг хамтад нь цуглуулах болно.

113 Мөн чөтгөр өөрийн их цэргийг, бүр тамын түмнийг хамтад нь цуглуулах болно; мөн Михаил хийгээд түүний их цэргийн эсрэг тулалдахаар өгсөн ирэх болно.

114 Мөн тэгээд агуу Бурханы “тулалдаан ирэх бөлгөө; мөн тэд гэгээнтнүүдийн дээр цаашид бүрмөсөн хүчгүй байхын тулд чөтгөр хийгээд

105a Илч. 14:8;

С ба Г 1:16.

106a су Бурханы Хурга.

^б 1 Кор. 15:25.

^в Иса. 63:3–4;

Илч. 19:15;

С ба Г 76:107;

133:50.

107a су Гэгээнтэн.

^б су Селестиел алдар суу.

^в су Өргөмжлөл.

^г С ба Г 76:95.

108a С ба Г 77:6–7.

^б Алма 37:25;

С ба Г 1:3.

110a С ба Г 84:100.

^б Илч. 20:1–3;

1 Ниф. 22:26;

С ба Г 101:28.

су Чөтгөр.

^в су Мянган жил.

111a С ба Г 29:22;

43:30–31.

112a су Михаил.

114a Илч. 16:14.

түүний их цэрэг байрандаа хаягдах болно.

115 Учир нь Михаил тэднийг бут ниргэж, мөн хаан сэнтийд залрах түүний, бүр Хурганы сэнтийг “эрэлхийлэх түүнийг дийлэх болно.

116 Энэ бол Бурханы мөн “ариусгагдагсдын алдар суу бөлгөө; мөн тэд цаашид ^бүхлийг үзэх нь үгүй.

117 Тиймийн тул, үнэнээр би та нарт хэлж байна, “найз нар минь, та нарт миний зарлигласанчлан, онцгой ариун хуралдайг хуралдуул.

118 Мөн бүгдээр итгэлгүй байгаа учраас, та нар хичээнгүйлэн эрэлхийлж мөн “мэргэн ухааны үгсийг бие биендээ ^бзаагтун; тийм ээ, мэргэн ухааны үгсийг шилдэг “номнуудаас эрэлхийлэгтүн та нар; бүр судлахаар мөн тэрчлэн итгэлээр, суралцахыг эрэлхийлэгтүн.

119 Өөрсдийгөө зохион байгуул; хэрэгтэй зүйл болгоныг бэлтгэ; мөн “өргөө, бүр залбирлын өргөө, мацгийн өргөө, итгэлийн өргөө, суралцахын өргөө, алдар суугийн өргөө, дэг журмын өргөө, Бурханы өргөөг байгуулагтун;

120 Та нарын оролтууд Их

Эзэний нэрэнд байж болохын тулд, та нарын гаралтууд Их Эзэний нэрэнд байж болохын тулд; та нарын бүхий л мэндчилгээнүүд, Бүхнээс Дээдэд өргөсөн гартайгаар Их Эзэний нэрэнд байж болохын тулд буюу.

121 Тиймийн тул, өөрсдийнхөө бүхий л хөнгөмсөг үг ярианаас, бүх “чанга инээдээс, бүхий л ^бтачаангуй хүслүүдээс, бүхий л “бардамнал хийгээд хөнгөмсөг зангаасаа, мөн бүхий л ёс бус үйлүүдээсээ ^бболигтун.

122 Өөрсдийнхөө дунд багшийг томил, мөн бүгдээрээ нэг зэрэг яригчид бүү байг; бүгдээрээ ярихад бүгдээрээ бүхнээс сэнхэрсэн байж болохын тулд, мөн хүн болгон тэгш боломжтой байж болохын тулд харин нэг нь хэсэг хугацаанд ярьж, мөн бүгдээрээ түүний хэлэхийг сонсог.

123 Та нар бие биенээ “хайрлахыг мэдэгтүн; ^бшунаг байхаа болигтун; сайн мэдээ үүнийг шаарддагчлан, бие биентэйгээ хуваалцаж сур.

124 “Залхуу байхаа болигтун; цэвэр ариун биш байхаа боль, бие биенээсээ дутагдал ^болж харахаа боль; шаардла-

115a Иса. 14:12–17;

Моисе 4:1–4.

116a су Өргөмжлөл;

Ариусгал.

^б Илч. 21:4;

Алма 11:45; 12:18;

С ба Г 63:49.

су Мөнх бус, Мөнх

бус байдал.

117a С ба Г 109:6.

118a су Мэргэн ухаан.

^б С ба Г 88:76–80.

су Заах, Багш.

^в С ба Г 55:4; 109:7, 14.

119a С ба Г 95:3;

97:10–17;

109:2–9; 115:8.

су Ариун Сүм, Их

Эзэний Өргөө.

121a С ба Г 59:15; 88:69.

^б су Тачаангуй,

Зуурдын.

^в су Бардамнал.

^г С ба Г 43:34; 100:7.

123a су Хайр.

^б су Шунах.

124a су Залхуурах,

Залхуу байдал.

^б С ба Г 64:7–10.

су Хилэнцэтийг

ярих.

гатайгаас илүү удаан унтахаа боль; та нар ядрахгүй байхын тулд; эрт босч бай, та нарын бие хийгээд оюун чинь амарч болохын тулд орондоо эрт орж бай.

125 Мөн бүх зүйлээс дээгүүр, мөн төгс чанар хийгээд “амар амгалангийн холбоо болох нөмрөг лугаа адил өөрсдийгөө ^бэнэрлийн холбоогоор хувцаслагтун.

126 Та нар намайг “ирэх хүртэл шантрахгүйн тулд ямагт ^бзалбирагтун. Болгоогтун, мөн харагтун, би гэнэт ирж, мөн та нарыг өөртөө хүлээн авах болно. Амен.

127 Мөн дахин, тэдэнд, бүр сүмийн бүх “ажилтны хувьд, эсвээс өөрөөр хэлбэл, дээд санваартнуудаас, бүр доош диконууд хүртэл сүмд тохиуулалд дуудагдсан тэдэнд шаардлагатай бүх зүйлд зааварлахын тулд байгуулагдсан ^ббошиглогчдын сургуулийн ерөнхийлөгчийн зөвлөлийн тулд, бэлтгэгдсэн өргөөний тогтсон журмыг буюу —

128 Мөн энэ нь уг сургуулийн ерөнхийлөгчийн зөвлөлийн өргөөний тогтсон журам болой: Ерөнхийлөгч байхаар томилогдсон тэрээр, эсвээс багш нь түүний тулд бэлтгэгдсэн байх өргөөнд байрандаа зогсож байхаар олддог байх ёстой.

129 Тиймийн тул, тэрээр

Бурханы өргөөнд эхнийх байх ёстой, уг өргөөнд цугларагсад түүний үгсийг чанга яриагаар биш, анхааралтай хийгээд тодоор сонсож болох бөлгөө.

130 Мөн тэрээр Бурханы өргөөнд ирэх үед, учир нь тэрээр уг өргөөнд эхнийх байх ёстой—болгоогтун, тэрээр үлгэр жишээ байж болохын тулд энэ нь үзэсгэлэнтэй болой—

131 Тэрээр үүрдийн гэрээний дохио буюу дурсамж болгон Бурханы өмнө өвдөг дээрээ залбирахад өөрийгөө “өргөг.

132 Мөн түүний дараа хэн нэг нь орж ирэхэд, багш мөн тэнгэр өөд гараа өргөн босч байг, тийм ээ, бүр ах буюу ах нараа эдгээр үгстэйгээр шууд мэндчилж байг:

133 Та нар ах уу эсвээс ах нар уу? Таныг “нөхөрлөлд хүлээн авах үүрдийн гэрээний дохио буюу дурсамж болгон, тогтоогдсон, хөдөлшгүй мөн хувиршгүй, шийдмэг байдалд, хайрын холбоонуудад Бурханы ач ивээлээр дамжуулан таны найз мөн ^бах байж, Бурханы бүх зарлигуудад үүрд мөн мөнхөд талархалтайгаар, буруугүйгээр алхахад Их Эзэн Есүс Христийн нэрээр би тантай мэндчилж байна. Амен.

134 Мөн энэхүү мэндчилгээнд зохистой бус нь мэдэгд-

125a су Амар амгалан.

б су Энэрэл.

126a С ба Г 1:12.

б су Залбирал.

127a су Албан тушаал,

Албан

тушаалтан.

б су Бошиглогчдын сургууль.

131a су Шүтэн

бишрэх.

133a су Нөхөрлөл.

б су Ах нар, Ах; Эгч.

дэг тэрээр та нарын дунд байртай байх ёсгүй; учир нь миний өргөө түүгээр “бохирлогдохыг та нар үл зөвшөөрөх ёстой.

135 Мөн орж ирэх мөн миний өмнө итгэлтэй тэр нь мөн ах, эсвээс ах нар болох тэд тэнгэр өөд гараа өргөж, мөн тэрхүү залбирал хийгээд гэрээгээр, эсвээс мөн тэрхүү дохионд, Амен гэж хэлэн ерөнхийлөгч буюу багшид мэндчилэх ёстой.

136 Болгоогтун, үнэнээр би та нарт хэлж байна, энэ бол Бурханы өргөөнд, бошиглогчдын сургуульд та нар бие биенээ мэндчилэх загвар болой.

137 Мөн энэ нь та нарын “сэнхрэлийн төлөөх ариун дуган, Ариун Сүнсний асар болж болохын тулд үүнийг залбирал хийгээд талархлаар,

Их Эзэний өргөөнд, бошиглогчдын сургуульд та нарын бүхий л үйлүүдэд Сүнсний өгөх үгээр үйлдэхээр та нар дуудагдсан билээ.

138 Мөн тэрээр энэ үеийнхний “цуснаас цэвэр байхаас өөр хэнийг ч, та нар өөрсдийн дунд энэ сургуульд хүлээн авах ёсгүй;

139 Мөн тэрээр хөл “угаах ёслолоор хүлээн авагдах ёстой, учир нь энэхүү төгсгөлд хөл угаах ёслол бий болсон билээ.

140 Мөн дахин хөл угаах ёслол нь ерөнхийлөгчөөр буюу сүмийн тэргүүлэх ахлагчаар гүйцэтгэгддэг байх ёстой.

141 Энэ нь залбирлаар эхэлдэг байх ёстой; мөн талх болон дарс “хүртсэний дараа миний талаарх Иоханы гэрчлэлийн арван гуравдугаар бүлэгт өгөгдсөн ⁶загварын дагуу тэрбээр бүсээ бүслэх ёстой.

ХЭСЭГ 89

1833 оны хоёрдугаар сарын 2-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:327–329). Анхны ах нар цуглаанууд дээр тамхи хэрэглэдэг байсны улмаас Бошиглогч энэ асуудлыг тунгаан бодоход хөтлөгдсөн байлаа; иймээс тэрээр энэ тухай Их Эзэнээс асуужээ. Мэргэн Ухааны Үг хэмээн нэрлэгддэг энэхүү илчлэлт үр дүн нь бөлгөө. Эхний гурван шүлэг нь тэнгэрлэгээр нөлөөлөгдсөн оршил хийгээд дүрслэл болон анх удаа Бошиглогчоор бичигдсэн байв.

1–9, Дарс хүчтэй ундаанууд, тамхи, мөн халуун ундаануудыг хэрэглэх нь хориглогдов; 10–17, Ургамлууд, жимс, мах мөн

үр тариа хүмүүн ба амьтдын хэрэглээний тулд томилогдов; 18–21, Сайн мэдээний хуульд, түүний дотор Мэргэн Ухааны

134a С ба Г 97:15–17;

110:7–8.

137a С ба Г 50:21–24.

138a С ба Г 88:74–75,

84–85.

139a су Угаах,

Угаагдах, Угаалга.

141a су Ариун ёслол.

6 Иохан 13:4–17.

Үгэнд дуулгавартай байх нь цаг зуурын хийгээд сүнсний адислалуудыг авчирдаг.

МЭРГЭН УХААНЫ ҮГ нь Көртландад цугласан дээд санваартнууд, мөн сүм, мөн тэрчлэн Сион дахь гэгээнтнүүдийн ашиг тусын тулд бөлгөө —

2 Мэндчилгээ илгээгдэхийн тулд; зарлигаар буюу албадлагаар бус харин эцсийн өдрүүдэд бүх гэгээнтний цаг зуурын аврал дахь Бурханы тогтсон журам хийгээд “тааллыг урагш үзүүлэх илчлэлтээр хийгээд мэргэн ухааны үгээр болой —

3 Гэгээнтнүүд, эсвээс гэгээнтнүүд хэмээн нэрлэгдэж болох бүх “гэгээнтнүүдийн сул доройчууд эсвээс хамгийн сул доройчуудын чадал боломжид тохирсон ⁶амлалт бүхий зарчмын тулд өгөгдсөн болой.

4 Болгоогтун, ийн Их Эзэн үнэнээр та нарт хэлдэг: “Хуйвалдагч хүмүүсийн зүрх сэтгэлд байгаа мөн эцсийн өдрүүдэд байх ⁶хилэнц хийгээд бодлуудын улмаас энэхүү мэргэн ухааны үгийг илчлэлтээр та нарт өгснөөр би та нарыг ⁶сэрэмжлүүлсэн билээ, мөн урьдаас сэрэмжлүүлж байна —

5 Та нарын дундах хэн нь ч гэсэн “дарс буюу хүчтэй ундаа уух тусам, энэ нь сайн бишийг болгоогтун, зөвхөн өөрсдөө түүний өмнө ариун ёслолуудад хамтран цугларахад төдийгүй мөн Эцэгийн тань мэлмийд ч үл нийцэх бөлгөө.

6 Мөн, болгоогтун, энэ нь дарс, тийм ээ, та нарын өөрсдийн хийсэн усан үзмийн “цэвэр дарс байх ёстой.

7 Мөн, дахин, “хүчтэй ундаанууд нь гэдэс дотрын тулд биш, харин та нарын биеийг угаахын тулд болой.

8 Мөн дахин, тамхи нь “биеийн тулд, мөн гэдэс дотрын тулд бус болой, мөн хүмүүнд сайн биш, харин хөх няц, өвчтэй бүх малд шийдвэр мөн ур чадвараар ашиглагдах ёстой.

9 Мөн дахин, халуун ундаанууд нь бие буюу гэдэс дотрын тулд биш бөлгөө.

10 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, хүмүүний үндсэн нөхцөл, мөн чанар хийгээд ашиглалтын тулд бүх эрүүл мэндэд тустай “ургамлуудыг Бурхан томилсон билээ—

11 Улирал дахь ургамал бүрийг, мөн улирал дахь жимс болгоныг, эдгээр бүгд нь,

89 1a су Мэргэн
Ухааны Үг.

2a С ба Г 29:34.

су Бурханы
зарлигууд.

3a су Гэгээнтэн.

б С ба Г 89:18–21.

4a су Нууц

хуйвалдаанууд.

б су Заль, Залилах,
Залилан.

в су Сэрэмжлэх,
Сэрэмжлүүлэг.

5a Лев. 10:9–11;

Иса. 5:11–12;

1 Кор. 6:10.

6a С ба Г 27:1–4.

7a Сур. үгс 20:1;
23:29–35.

8a 1 Кор. 3:16–17.

су Бие.

10a ө.х. Ургамлууд.

Эхл. 1:29.

С ба Г 59:17–20.

ухаалгаар хийгээд “талархалтайгаар ашиглагдах ёстой.

12 Тийм ээ, “амьтад хийгээд агаарын жигүүртнүүдийн ^бмахыг Их Эзэн бибээр тэрчлэн хүмүүн талархалтайгаар ашиглахын тулд томилсон билээ; гэсэн хэдий ч, тэдгээр нь ^арвич хямгачаар ашиглагдах ёстой;

13 Мөн тэдгээр нь гагцхүү өвлийн цагт, эсвээс хүйтэнд, эсвээс өлсгөлөнгөөс бусад үед ашиглагддаггүй байх нь миний таашаалд нийцнэ.

14 Бүх “үр тариа нь хүмүүн хийгээд амьтад ашиглахын тулд, амьдралын тулгуур байхын тулд, зөвхөн хүмүүнд төдийгүй тэжээмэл амьтад, мөн тэнгэрийн жигүүртнүүд, мөн газар дээр явдаг буюу мөлхдөг бүх зэрлэг амьтанд томилогдсон болой;

15 Мөн эдгээрийг гагцхүү өлсгөлөнгийн хийгээд их өлссөн цагт хүмүүн ашиглахын тулд Бурхан хийсэн юм.

16 Бүх үр тариа хүмүүний хүнсэнд сайн; усан үзмийн модны жимс ч тэрчлэн адил; газарт ч байна уу, эсвээс газрын дээгүүр ч байна уу, жимс ургуулдаг тэр нь болой;

17 Гэсэн хэдий ч, улаан буудай нь хүмүүний тулд, мөн эрдэнэ шиш нь үхрийн тулд, мөн овъёос нь адууны тулд, мөн хөх тариа нь шувууд болоод гахайн тулд, мөн тэжээмэл амьтдын тулд, мөн арвай нь бүх ашигтай амьтдын тулд, мөн тэрчлэн бусад үр тариа нь зөөлөн ундаануудын тулд бөлгөө.

18 Мөн зарлигуудад дуулгавартай байдалд алхан, эдгээр айлдваруудыг санаж мөн хэрэгжүүлдэг бүх гэгээнтнүүд хүйсэндээ “эрүүл энхийг хийгээд яснууддаа чөмөг хүлээн авах болно;

19 Мөн “мэргэн ухаан хийгээд ^бмэдлэгийн агуу сан хөмрөгүүдийг, бүр нуугдмал сан хөмрөгүүдийг олж авах болно;

20 Мөн “гүйхэд мөн ядрах нь үгүй, мөн алхахад мөн цуцах нь үгүй байх болно.

21 Мөн устгагч тэнгэр элч, Израилын хүүхдүүдийн “дэргэдүүр өнгөрсний адил тэдний дэргэдүүр өнгөрч, мөн тэднийг хөнөөхгүй байх болно хэмээх ^бамлалтыг Их Эзэн бибээр тэдэнд өгч байна. Амен.

ХЭСЭГ 90

1833 оны гуравдугаар сарын 8-нд Огайогийн Көртландад Бошилогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:329–331). Энэхүү илчлэлт нь Тэргүүн Зөвлөл байгуулахад хийсэн алхмын үргэлжлэл (хэсэг 81-ийн толгой гарчгийг үз) болой; үүний

11a су Талархалтай, Талархах, Талархал өргөх.	б Эхл. 9:3; Лев. 11:1–8. в С ба Г 59:20.	б су Мэдлэг; Гэрчлэл.
12a 1 Тим. 4:3–4; С ба Г 49:18–21.	14a Дан. 1:6–20. 18a Сур. үгс 3:8. 19a су Мэргэн ухаан.	20a Иса. 40:31. 21a Ег. 12:23, 29. б С ба Г 84:80.

дүнд, дурдагдсан зөвлөхүүд 1833 оны гуравдугаар сарын 18-нд томилогдсон ажээ.

1-5, Хаант улсын түлхүүрүүд Иосеф Смитэд мөн түүгээр дамжин Сүмд итгэмжлэгдэв; 6-7, Сидней Ригдон мөн Фредерик Г. Виллямс нар Тэргүүн Зөвлөлд үйлчлэх ёстой; 8-11, Сайн мэдээ Израилын үндэстнүүдэд, харийнханд, мөн иудейчүүдэд, өөрийнхөө хэлээр сонсох хүн болгонд номлогдох ёстой; 12-18, Иосеф Смит мөн түүний зөвлөхүүд Сүмийг цэгцлэх ёстой; 19-37, Өөр өөр хувь хүмүүс цэх шулуун алхаж мөн түүний хаант улсад үйлчлэхээр Их Эзэнээр зөвлөгдөв.

ҮНЭНЭЭР, үнэнээр гуйлтын чинь дагуу нүглүүд чинь чамд “өршөөгдсөн болой хүү минь, учир нь чиний залбирлууд хийгээд ах нарын чинь залбирлууд миний сонорт ирсэн хэмээн Их Эзэн би ийн хэлж байна.

2 Тиймийн тул, энэ цагаас эхлэн чамд өгөгдсөн хаант улсын “түлхүүрүүдийг, эцсийн удаа урагш ирэх тэрхүү ^бхаант улсынхыг авч явахаар адислагдсан болой чи.

3 Үнэнээр би чамд хэлж байна, энэ хаант улсын түлхүүрүүд чамайг дэлхийд байхад, мөн ирэх дэлхийд ч, хэзээ ч чамаас авагдах нь үгүй;

4 Гэсэн хэдий ч, чамаар дам-

жин “зөгнөлүүд, өөр нэгэнд, тийм ээ, бүр сүмд өгөгдөх ёстой.

5 Мөн тэдгээр нь хөнгөмсөг зүйл хэмээн тооцогдож, мөн үүний улмаас буруушаалт дор авчрагдан, мөн шуурга бууж ирэн мөн салхи үлээхэд бас “бороо бууж, мөн орон байрыг нь цохих үед бүдэрч мөн унахгүйн тулд Бурханы зөгнөлүүдийг хүлээн авдаг тэд бүгд, тэдгээрийг хэрхэн авч явахад ^бболгоомжтой байг.

6 Мөн дахин, чиний ах нар, Сидней Ригдон, Фредерик Г.Виллямс хоёрт би үнэнээр хэлж байна, нүглүүд нь тэрчлэн тэдэнд өршөөгдсөн болой, энэхүү эцсийн хаант улсын түлхүүрүүдийг атгахад тэд чамтай адил тэгшид тооцогдох болой;

7 Тэрчлэн миний үйлчлэлээр дамжуулан зохион байгуулагдахыг нь миний зарлигласан бошиглогчдын “сургуулийн түлхүүрүүдийг мөн адил;

8 Сионы мөн Израилын үндэстнүүдийн, мөн харийнханы, итгэх болгоны авралын төлөөх өөрсдийн тохинуулалд тэд үүгээр төгөлдөржиж болохын тулд бөлгөө;

9 Чиний үйлчлэлээр дамжуулан тэд үгийг хүлээн авч

90 1a су Уучлах.

2a С ба Г 65:2.

су Санваарын түлхүүрүүд.

б су Бурханы хаант улс буюу Тэнгэ-

рийн хаант улс.

4a Үйлс 7:38; Ром. 3:2;

Евр. 5:12;

С ба Г 124:39, 126.

су Бошиглох, Бошиглол.

5a Мат. 7:26-27.

б С ба Г 1:14.

7a су Бошиглогчдын сургууль.

болохын тулд, мөн тэдний үйлчлэлээр дамжин үг нь дэлхийн хязгааруудад, “эхлээд” харийнханд, мөн тэгээд болгоогтун, мөн харагтун, тэд иудейчүүд уруу эргэхийн тулд урагш одож болохын тулд бөлгөө;

10 Мөн тэгээд үндэстнүүдийг, Бурханыг мэддэггүй үндэстнүүдийг, “Иосефын угсааг, тэдний авралын сайн мэдээнд итгүүлэхийн тулд Их Эзэний гар сүр хүчээрээ дамжин” илчлэгдэх тэрхүү өдөр ирэх болой.

11 Учир нь мөнхүү улиран тохиох дор Есүс Христийн илчлэлтийн учир тэдэн дээр урагш юүлэгдэх “Тайтгаруулагчийн чиглүүлээр энэ” хүчинд “томилогдсон тэднээр дамжуулан тэрхүү өдөр хүн болгон сайн мэдээний бүрэн байдлыг төрөлх хэл дээрээ, мөн өөрийн хэлээр” сонсох болно.

12 Мөн эдүгээ, үнэнээр би та нарт хэлж байна, “тохиуулалд хийгээд ерөнхийлөгчийн зөвлөлүүддээ та нар үргэлжлүүл хэмээх зарлигийг би та нарт өгч байна.

13 Мөн та нар бошиглогч-

дын орчуулгыг дуусгасан үеэсээ хойш сүмийн хийгээд уг “сургуулийн ажил хэргүүдийг” тэргүүлэх ёстой.

14 Мөн Тайтгаруулагчаар илэрхийлэгдэх үед цагаас цагт хаант улсын “нууцуудыг нээх” илчлэлтүүдийг хүлээн авах болой;

15 Мөн сүмүүдийг цэгцэл, мөн “судалж мөн” суралц, мөн бүх сайн номнууд, “хэлнүүд, мөн хүмүүстэй танилц.

16 Мөн зөвлөлд тэргүүлэх, мөн энэ сүмийн хийгээд хаант улсын бүх ажил хэргийг цэгцлэх нь та нарын бүх амьдрал дахь та нарын ажил хийгээд үүрэг даалгавар байх болно.

17 “Ичгүүрлэгдсэн, мөн мадлагдсан бүү бай; харин өөрийн бүхий л ихэмсэг зан хийгээд” бардамналд сануулагдаж бай, учир нь энэ нь сүнсэнд чинь занга тавьдаг билээ.

18 Гэр орноо цэгцэл; “залхуу хойрго байдал хийгээд” цэвэр ариун бус явдлыг өөрөөсөө холдуул.

19 Эдүгээ, үнэнээр би чамд хэлж байна, чиний зөвлөх хийгээд бичээч, бүр Фреде-

9a Мат. 19:30;
Ифер 13:10–12.
б 1 Ниф. 13:42;
С ба Г 107:33; 133:8.
10a Эхл. 49:22–26;
1 Ниф. 15:13–14.
б С ба Г 43:23–27;
88:84, 87–92.
11a су Тайтгаруулагч.
б су Санваартан.
в су Дуудах,
Бурханаас
дуудагдах,

Дуудлага; Томилох,
Томилолт.
г су Номлолын
ажил.
12a су Тохинуулагч.
13a су Бошиглогчдын
сургууль.
б С ба Г 107:91–92.
14a су Бурханы
нууцууд.
б су Илчлэлт.
15a С ба Г 88:76–80, 118;
93:53.

б С ба Г 107:99–100;
130:18–19.
в су Хэл.
17a Ром 1:16;
2 Ниф. 6:13.
б С ба Г 88:121.
су Бардамнал.
18a С ба Г 58:26–29.
су Залхуурах,
Залхуу байдал.
б С ба Г 38:42.

рик Г.Виллямсын гэр бүлийн тулд, нэг газар аль болох түргэн бий болгодог.

20 Мөн миний “настай үйлчлэгч, Ахмад Иосеф Смит одоогийн амьдарч байгаа газартаа гэр бүлийнхээ хамт үргэлжлүүлэн амьдраг, мөн Их Эзэний ам нэрлэх хүртэл энэ нь бүү зарагдаг;

21 Миний зөвлөх бүр Сидней “Ригдон, Их Эзэний ам нэрлэх хүртэл одоогийн амьдарч байгаа газартаа үлдэг.

22 Мөн бишоп, “төлөөний хүнийг олж авахаар хичээнгүйлэн эрэг, мөн тэр нь баялагууд хураасан—хүчтэй итгэл бүхий, Бурханы хүн байг—

23 Их Эзэний агуулах хүмүүсийн нүдний өмнө муу нэрэнд авчрагдахгүйн тулд тэрээр өр болгоныг төлөх боломжтой байж болно;

24 “Хичээнгүйлэн судлагтун, үргэлж залбирагтун, мөн итгэлтэй байгтун, мөн хэрэв та нар цэх шулуун алхаж мөн та нар бие биентэйгээ гэрээнд орсон тэрхүү гэрээг санах аваас, мөн та нарын сайн сайхны тулд бүх зүйл хамтдаа ажиллах болно.

25 Та нарын, ялангуяа миний настай үйлчлэгч Ахмад Иосеф Смитийн гэр бүл, та нарын гэр бүлд үл хамаарах тэднийг оролцуулан, “цөөн байг;

26 Миний ажлыг тохиолгохоор авчрахын тулд та нарын тулд бий болгогдсон тэдгээр зүйлүүд та нараас авагдаж мөн зохистой бус тэдэнд өгөгдөхгүйн тулд буюу—

27 Мөн үүгээр та нарт миний зарлигласан тэдгээр зүйлүүдийг гүйцэлдүүлэхэд та нарт саад учруулагдах болно.

28 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, миний гарын үйлчлэгч Виенна Жаквес зардлуудаа төлөх мөн Сионы нутагт өгсөн очихын тулд мөнгө хүлээн авах ёстой нь миний таалал юм;

29 Мөн үлдсэн мөнгө нь надад ариулан адислагдаж болох бөлгөө, мөн тэрбээр миний өөрийн тогтоосон цагт шагнагдах болно.

30 Үнэнээр би та нарт хэлж байна, тэрбээр Сионы нутагт өгсөн очиж, мөн бишопын гараас өвийг хүлээн авах нь миний мэлмийд нийцэх буюу;

31 Тэрбээр итгэлтэй байж, мөн үүнээс хойш өөрийн өдрүүддээ залхуу байхгүйн хэрээр, тэрбээр амар амганд суурьшиж болохын тулд бөлгөө.

32 Мөн болгоогтун, үнэнээр би та нарт хэлж байна, та нар энэ зарлигийг бичиж, мөн би өөрийнхөө тогтоосон цагт та нарыг тэрчлэн Сионы дээр

20a су Ахмад Иосеф Смит.

21a су Сидней Ригдон.

22a С ба Г 84:112–113.

б Иаков 2:17–19.

24a су Хичээл зүтгэл.

б су Залбирал.

в су Гэрээ.

г Езра 8:22; Ром 8:28;

С ба Г 100:15;

122:7–8.

25a ө.х. Ахмад Иосеф

Смитийн санаа

тавьдаг байсан

ядуучууд.

“тэргүүлэхээр дуудсаныг Сион дахь ахан дүүстээ хайраар мэндчилэн хэлэх ёстой.

33 Тиймийн тул, энэ асуудлын талаар тэд намайг ядраахаа болиг.

34 Болгоогтун, Сион дахь та нарын ахан дүүс наманчилж эхлэн, мөн тэнгэр элчүүд тэдний дээр баясах ажгуу гэдгийг би та нарт хэлж байна.

35 Гэсэн хэдий ч, олон зүйл миний таашаалд эс нийцэх бөлгөө; мөн миний үйлчлэгч “Виллям Э.МакЛеллин, мөн

миний үйлчлэгч Сидней Гилберт ч, миний таашаалд үл нийцэх бөлгөө; мөн тэрчлэн бишопт ч, мөн бусдад нь ч наманчлах зүйл олон буй.

36 Гэвч үнэнээр би та нарт хэлж байна, Их Эзэн бибээр “Сионтой тэмцэж, мөн түүний хүчирхэг нэгнүүдийг өмгөөлж, мөн тэр ялж мөн миний өмнө “цэвэр ариун байх хүртэл түүнийг “гэсгээн цээрлүүлэх болно.

37 Учир нь тэр байрнаасаа хөдөлгөгдөх нь үгүй. Их Эзэн, бибээр үүнийг ярилаа. Амен.

ХЭСЭГ 91

1833 оны гуравдугаар сарын 9-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:331–332). Бошиглогч энэ үед Хуучин Гэрээг орчуулан завгүй байлаа. Апокриф хэмээгдэх эртний бичээсүүдийн хэсэгт хүрч ирээд, тэрээр Их Эзэнээс асууж, тэгээд энэхүү зааврыг хүлээн авчээ.

1–3, Апокриф нь ихэнхдээ зөв орчуулагдсан хэдий ч хүмүүний гараар хийгдсэн олон буруу оруулгыг агуулдаг; 4–6, Энэ нь Сүнсээр гэгээрсэн тэдэнд ашиг тус өгдөг.

АПОКРИФЫН тухайд — Олон зөв зүйл тэнд агуулагддаг, мөн энэ нь ихэнхдээ зөв орчуулагдсаныг Их Эзэн та нарт ийн хэлж байна;

2 Хүмүүний гараарх оруулгууд болох олон буруу зүйл тэнд агуулагддаг болой.

3 Үнэнээр, би чамд хэлж байна, Апокриф орчуулагдах ёстой нь шаардлагатай бус бөлгөө.

4 Тиймийн тул, үүнийг унших хэн боловч тэрээр “ойлгог, учир нь Сүнс үнэнийг илэрхийлдэг бөлгөө;

5 Мөн “Сүнсээр гэгээрдэг хэн боловч, тэндээс ашиг тусыг олж авах болно.

6 Мөн Сүнсээр үл хүлээн авах хэн боловч ашиг тусыг

32a С ба Г 107:91–92.
35a С ба Г 66:1; 75:6–9.
36a су Сион.
б су Цэвэр ариун,
Цэвэр ариун

байдал.
в су Зэмлэх, Зэмлэл.
91 1a су Апокриф.
4a су Мэдлэг.
5a су Ариун Сүнс;

Сүнсний
удирдамж,
Сүнслэгээр
нөлөөлөгдөх.

олж чадах нь үгүй. Тиймийн тул, энэ нь орчуулагдах

ёстой нь шаардлагатай бус юм. Амен.

ХЭСЭГ 92

1833 оны гуравдугаар сарын 15-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:333). Зөвлөх байхаар Тэргүүн Зөвлөлд өмнөхөн нь томилогдсон Фредерик Г.Виллямст уг илчлэлт чиглэгджээ.

1–2, Нэгдсэн журамд орохтой холбогдсон зарлигийг Их Эзэн өгөв.

ӨМНӨ нь өгөгдсөн зарлигт нийцэн зохион байгуулагдсан, “нэгдсэн журамд та нар түүнийг хүлээн ав хэмээх өөрийн үйлчлэгч Фредерик Г.Виллямсын талаар нэг илчлэлт мөн зарлигийг би нэгдсэн журамд өгч бай-

на хэмээн Их Эзэн ийн хэлж байна. Бибээр нэгд хэлдгээ бүгдэд хэлдэг болой.

2 Мөн дахин, миний үйлчлэгч Фредерик Г.Виллямс, би чамд хэлж байна, чи энэ журамд цог золбоотой нэг гишүүн нь байх болно; мөн чи өмнөх бүх зарлигийг сахихад итгэлтэй байхын хэрээр чи үүрд адислагдах болно. Амен.

ХЭСЭГ 93

1833 оны тавдугаар сарын 6-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:343–346).

1–5, Итгэлтэй бүгд Их Эзэнийг харах болно; 6–18, Бурханы Хүү Эцэгийнхээ алдар суугийн бүрэн байдлыг хүлээн авах хүртлээ ач ивээлээс ач ивээлд явж байсныг Иохан гэрчилсэн бөлгөө; 19–20, Ач ивээлээс ач ивээлд явагч бүх хүмүүс тэрчлэн түүний бүрэн байдлыг хүлээж авах болно; 21–22, Христээр дамжин төрдөг тэд Ууган Хүүгийн Сүм юм; 23–28, Христ бүх үнэний бүрэн байдлыг хүлээн авсан юм, мөн хүмүүн дуулгавартай байдлаар

үүний нэгэн адил үйлдэж болно; 29–32, Хүмүүн эхлэлд Бурхантай хамт байв; 33–35, Элементүүд мөнх юм, мөн амилуулалтад хүмүүн бүрэн баяр хөөрийг хүлээн авч болно; 36–37, Бурханы алдар суу нь оюун билиг юм; 38–40, Христийн Гэтэлгэлийн учир хүүхдүүд Бурханы өмнө гэм нүгэлгүй бөлгөө; 41–53, Удирдагч ах нар гэр бүлээ цэгцлэхээр зарлигдуулав.

ҮНЭНЭЭР Их Эзэн ийн хэлдэг: Мөнхүү улиран

тохиох дор нүглээ “орхиж мөн надад ирдэг, мөн миний нэрийг ^бдууддаг, мөн дуу хоолойг минь ^ддуулгавартай дагадаг, мөн зарлигуудыг минь сахьдаг бодгаль болгон миний ^ннүүрийг ^ахарж мөн намайг байдгийг мэдэх болно;

2 Мөн би бол дэлхийд ирдэг хүн болгоныг гэрэлтүүлдэг үнэн ^ггэрэл гэдгийг;

3 Мөн бибээр ^эЭцэгт буй, мөн Эцэг надад, мөн Эцэг бид хоёр нэг гэдгийг —

4 Тэрбээр өөрийн бүрэн байдлыг надад ^өөгсний ^уучир Эцэг, мөн би дэлхийд байж мөн ^{ма}махан бодийг өөрийн асар болгон мөн хүмүүний үрсийн дунд аж төрж байсны учир Хүү бөлгөө.

5 Бибээр дэлхийд байж мөн Эцэгээс хүлээн авсан билээ, мөн түүний ^{аж}ажлууд тодорхой илэрхийлэгдсэн юм.

6 Мөн ^ИИохан миний ^аалдар суугийн бүрэн байдлыг харж мөн гэрчилсэн билээ, мөн ^ИИоханы цэдгийн бүрэн байдал нь үүнээс хойш илчлэгдэх болно.

7 Мөн тэрбээр гэрчлэн, хэлсэн нь: дэлхийн өмнө, ^{эх}эхлэлд байсан түүний алдар сууг би харсан хэмээжээ;

8 Тиймийн тул, ^{үг}үг нь эхлэлд байсан бөлгөө, учир нь тэрбээр Үг, бүр авралын элч байв —

9 ^ГГэрэл мөн дэлхийн ^ГГэтэлгэгч; дэлхий түүгээр хийгдэж мөн хүмүүний амьдрал хийгээд хүмүүний гэрэл түүнд байсан учраас, дэлхийд ирсэн үнэний Сүнс болой.

10 Дэлхийнүүд түүгээр ^ххийгдсэн байлаа; хүмүүн түүгээр хийгдсэн байлаа; бүх зүйл түүгээр мөн түүгээр дамжин мөн түүнээс хийгдсэн байлаа.

11 Мөн махан бодид ирж мөн оршиж байсан мөн бидний дунд оршин байсан үнэний Сүнсээр дүүрэн, бүрэн ач ивээл хийгээд үнэн, Эцэгийн Төрсөн Ганцын алдар суу болох түүний алдар сууг би болгоосноо, Иохан бибээр гэрчилдэг.

12 Мөн тэрээр эхлээд ^{бүрэн}бүрэн байдлыг хүлээн авсан нь үгүй, харин ^{ач}ач ивээл дээр

93 1а су Наманчлах, Наманчлал; Зөв зохистой, Зөв зохистой байдал.
б Иоел 2:32.
в су Дуулгавартай байх, Дуулгавартай, Дуулгавартай дагах.
г исо, 1 Иоан 4:12.
д Ег. 33:11;
С ба Г 38:7–8;
67:10–12; 88:68;
101:23; 130:3.
су Тайтгаруулагч.
2а Иоан 1:4–9;

С ба Г 14:9;
84:45–47; 88:6–7.
су Гэрэл, Христийн гэрэл.
3а Иоан 10:25–38;
17:20–23;
С ба Г 50:43–45.
4а су Есүс Христ—Эрх мэдэл.
б Мозая 15:1–7.
в Лук 1:26–35; 2:4–14;
3 Ниф. 1:12–14;
Ифер 3:14–16.
5а Иоан 5:36; 10:25;
14:10–12.
6а Иоан 1:34.

б су Есүс Христ— Есүс Христийн алдар суу.
в Иоан 20:30–31.
7а Иоан 1:1–3, 14;
17:5; С ба Г 76:39.
8а су Есүс Христ; Иехова.
9а су Гэрэл, Христийн гэрэл.
б су Гэтэлгэгч.
10а Евр. 1:1–3;
С ба Г 76:24;
Мосе 1:31–33.
12а Филип. 2:6–11.
б Иоан 1:16–17.

ач ивээлийг хүлээн авсныг Иохан бибээр харсан билээ;

13 Мөн тэрээр эхлээд бүрэн байдлыг хүлээн авсан нь үгүй, харин тэрээр бүрэн байдлыг хүлээн авах хүртлээ “ач ивээлээс ач ивээлд үргэлжлүүлж байлаа;

14 Мөн тэрээр эхлээд бүрэн байдлыг хүлээж аваагүйн улмаас тэрээр ийн Бурханы “Хүү хэмээн дуудагддаг байв.

15 Мөн “Иохан, бибээр, мөн харагтун, тэнгэр нээгдсэнийг, мөн ^аАриун Сүнс ^атагтаа хэлбэрээр түүн дээр бууж ирснийг, мөн түүн дээр суусныг, мөн тэнгэрээс дуу хоолой ирж: Энэ бол миний ‘хайртай Хүү хэмээн хэлснийг гэрчилдэг.

16 Мөн тэрээр Эцэгийн сүр жавхлангийн бүрэн байдлыг хүлээн авсныг Иохан, бибээр гэрчилж байна;

17 Мөн тэрээр тэнгэрт хийгээд газар дээрх “бүх ^бхүчийг аль алинд нь хүлээн авсан бөгөөд “Эцэгийн алдар суу түүнтэй хамт байв, учир нь тэрээр түүнд оршиж байлаа.

18 Мөнхүү улиран тохиох дор хэрэв та нар итгэлтэй байх аваас Иоханы цэдгийн бүрэн байдлыг та нар хүлээж авах болно.

19 Мөн та нар хэрхэн шүтэхээ мэдэж мөн ойлгож, мөн та нар юуг “шүтэхээ мэдэж болохын тулд, миний нэрээр та нар Эцэгт ирж, мөн тогтоосон цагт түүний бүрэн байдлыг хүлээж авч болохын тулд эдгээр айлдваруудыг би та нарт өгдөг.

20 Учир нь хэрэв та нар миний “зарлигуудыг сахих аваас, та нар түүний ^ббүрэн байдлыг хүлээн авч, мөн би Эцэгт байдаг лугаа адил надаар ^аалдарших болно; тиймийн тул, би та нарт хэлдэг, та нар ‘ач ивээл дээр ач ивээлийг хүлээж авах болно.

21 Мөн эдүгээ, үнэнээр би та нарт хэлж байна, “эхлэлд би Эцэгтэй хамт байсан билээ, мөн ^бУуган Хүү нь мөн болой.

22 Надаар дамжин төрдөг тэд бүгд, мөнхүү түүний “сүр жавхлангаас ^бхүртэгчид, мөн Ууган Хүүгийн сүм бөлгөө.

23 Эхлэлд та нар тэрчлэн

13a Лук 2:52.

14a Лук 1:31–35;

С ба Г 6:21.

су Бурхан, Бурхан тэргүүтэн —Хүү Бурхан.

15a Иохан 1:29–34.

б су Ариун Сүнс.

в су Тагтааны тэмдэг.

г Мат. 3:16–17.

17a Мат. 28:18;

Иохан 17:2;

1 Петр 3:22.

б су Есүс Христ—Эрх мэдэл; Хүч.

в су Бурхан, Бурхан тэргүүтэн —Эцэг Бурхан.

19a Иохан 4:21–26; 17:3;

Үйлс 17:22–25.

су Шүтэн бишрэх.

20a С ба Г 50:28.

б Иохан 1:16;

С ба Г 84:36–39.

в Иохан 17:4–5, 22.

су Хүмүүн, Хүмүүс—Хүн, Тэнгэрлэг Эцэгтэй адил болох боломж.

г су Ач ивээл.

21a Иохан 1:1–2;

1 Петр 1:19–20;

Мосе 4:2.

б су Анх төрсөн.

22a су Селестиел алдар суу.

б 1 Петр 5:1;

С ба Г 133:57.

Эцэгтэй “хамт байж мөн Сүнс байсан билээ; бүр үнэний Сүнс буюу;

24 Мөн “үнэн бол байгаа юмсын, байсан зүйлүүдийн, мөн ирэх зүйлүүдийн тухай ^бмэдлэг юм;

25 Мөн үүнээс ^аилүү буюу дутуу байх ямар ч зүйл бол эхлэлээс ^бхудалч асан ёс бус нэгний сүнс юм.

26 “Үнэний Сүнс бол Бурханых юм. Би бол үнэний Сүнс, бас: Тэрээр үнэний бүрэн байдлыг, тийм ээ, бүр бүх үнэнийхийг хүлээн авсан хэмээн хэлж Иохан миний тухай гэрчилсэн билээ;

27 Мөн түүний зарлигуудыг сахихаас бусдаар, хүмүүн “бүрэн байдлыг хүлээн авах нь үгүй.

28 Түүний зарлигуудыг “сахьдаг тэрээр, үнэнд тэрээр алдаршиж мөн бүх зүйлийг ^бмэдэх хүртлээ үнэн ба ^агэрлийг хүлээж авдаг болой.

29 “Эхлэлд хүмүүн тэрчлэн Бурхантай хамт байсан юм. ^бОюун билиг буюу үнэний гэрэл нь бүтээгдээгүй

буюу хийгдээгүй юм, мөн чухамдаа ийм байж ч чадахгүй болой.

30 Бүх үнэн нь Бурхан байрлуулсан тэрхүү хүрээнд, тэрчлэн бүх оюун билгийн адил өөрийнхөө төлөө бие даасан байдалтай “байдаг; эс тэгвээс оршин тогтнол байх нь үгүй болой.

31 Болгоогтун, энэ бол хүмүүний “эрх чөлөө, мөн энэ бол хүмүүний буруушаалт болой; учир нь эхлэлээс байсан тэр нь тэдэнд ^бтодорхой илэрхийлэгдсэн билээ, мөн тэдгээр нь гэрлийг хүлээн авдаггүй бөлгөө.

32 Мөн сүнс нь “гэрлийг хүлээн авдаггүй хүн болгон буруушаалт дор байдаг ажгуу.

33 Учир нь хүмүүн бол “сүнс юм. ^бЭлементүүд мөнх юм, мөн салшгүй холбогдсон сүнс ба элемент нь баяр хөөрийн бүрэн байдлыг хүлээн авдаг;

34 Мөн эдгээр нь “салахад, хүмүүн ^ббаяр хөөрийн бүрэн байдлыг хүлээн авч чадахгүй.

23a су Хүмүүн,
Хүмүүс—Хүн,
Тэнгэрлэг Эцэгийн
сүнсэн хүүхэд.

24a су Үнэн.

б су Мэдлэг.
25a С ба Г 20:35.

б Иохан 8:44;
2 Ниф. 2:18;
Моце 4:4.

26a Иохан 14:6.

27a су Төгс.

28a су Дуулгавартай
байх, Дуулгавар-
тай, Дуулгавартай

дагах.
б Иохан 17:3;
С ба Г 88:49, 67.
в С ба Г 50:24; 84:45.
су Гэрэл, Христийн
гэрэл.

29a Абр. 3:18.
су Мөнх бус
байдлын өмнөх
амьдрал; Хүмүүн,
Хүмүүс.

б су Оюуны өндөр
хөгжил.

30a 2 Ниф. 2:13–27.

31a су Сонгох эрх.

б Дэд хууль 30:11–14;
С ба Г 84:23–24.

32a су Гэрэл, Христийн
гэрэл; Үнэн.

33a С ба Г 77:2;
Абр. 5:7–8.

су Хүмүүн,
Хүмүүс—Хүн,
Тэнгэрлэг Эцэгийн
сүнсэн хүүхдүүд.

б С ба Г 131:7–8; 138:17.
су Амилуулалт.

34a 2 Ниф. 9:8–10.

б су Баяр баясгалан.

35 “Элементүүд бол Бурханы асар юм; тийм ээ, хүмүүн бол Бурханы асар, бүр ⁶ариун сүмүүд бөлгөө; мөн ямар ч ариун сүм бузарлагдвал, Бурхан тэрхүү ариун сүмийг устгах болно.

36 Бурханы “алдар суу бол ⁶оюун билиг, эсвээс, өөрөөр хэлбэл, “гэрэл ба үнэн юм.

37 Гэрэл ба үнэн нь тэрхүү “хилэнцэт нэгнийг орхидог.

38 Хүмүүний сүнс болгон эхлэлд “гэм зэмгүй байв; мөн Бурхан хүмүүнийг ⁶уналтаас “гэтэлгэснээр, хүмүүн өөрсдийн нялх балчир байдалд, Бурханы өмнө дахин “гэм зэмгүй болсон бөлгөө.

39 Мөн тэрхүү ёс бус нэгэн ирж, дуулгаваргүй байдлаар дамжуулан мөн эцгүүдийнх нь “уламжлалын улмаас гэрэл ба үнэнийг хүмүүний үрсээс холдуулан ⁶аваачдаг бөлгөө.

40 Харин “хүүхдүүдээ гэрэл ба үнэнд хүмүүжүүлэхийг би та нарт зарлигласан билээ.

41 Харин миний үйлчлэгч Фредерик Г.Виллямс чамд би үнэнээр хэлж байна,

чи энэхүү буруушаалт дор үргэлжлэн байна;

42 Чи зарлигуудын дагуу гэрэл ба үнэнийг хүүхдүүддээ “заасангүй; мөн нөгөөх ёс бус нэгэн, чиний дээр хүчтэй хэвээр байна, мөн энэ нь чиний зовлон зүдгүүрийн шалтгаан болой.

43 Мөн эдүгээ би чамд зарлиг өгч байна—хэрэв чи чөлөөлөгдөхийг хүсэх аваас, чи гэр орноо “цэгцлэх ёстой, учир нь зөв бус олон зүйл гэр оронд чинь байна.

44 Үнэнээр, би өөрийн үйлчлэгч Сидней Ригдонд хэлж байна, зарим зүйлд тэрээр хүүхдүүдийнхээ талаарх зарлигуудыг сахьсангүй; тиймийн тул, эхлээд гэр орноо цэгцэл.

45 Үнэнээр, би өөрийн үйлчлэгч Бага Иосеф Смитэд хэлж байна, эсвээс, өөрөөр хэлбэл би та нарыг “найз нараа гэж дуудах болно, учир нь та нар миний найз нар билээ, мөн та нар надтай хамт өв авах болно—

46 Дэлхийн тусын тулд би та нарыг “үйлчлэгчдээр дуудсан билээ, мөн та нар миний

35a С ба Г 130:22.

б 1 Кор. 3:16–17.

36a су Алдар суу;

Есүс Христ—
Есүс Христийн
алдар суу.

б С ба Г 130:18–19;

Абр. 3:19.

су Оюуны өндөр
хөгжил.

в С ба Г 88:6–13.

37a Моисе 1:12–16.

су Чөтгөр.

38a су Гэм зэмгүй,

Гэмгүй.

б су Адам, Ева

хоёрын уналт.

в Мозая 27:24–26;

Моисе 5:9; ИТ 1:3.

су Гэтэлгэх,

Гэтэлгэгдэх,

Гэтэлгэл.

г Моро. 8:8, 12, 22;

С ба Г 29:46–47.

су Аврал—

Хүүхдүүдийн

аврал.

39a Езек. 20:18–19;

Алма 3:8.

су Уламжлалууд.

б Мат. 13:18–19;

2 Кор. 4:3–4;

Алма 12:9–11.

40a су Гэр бүл—Эцэг
эхийн хариуцлага.

42a 1 Сам. 3:11–13;

С ба Г 68:25–31.

43a 1 Тим. 3:4–5.

45a С ба Г 84:63; 88:62.

46a Лев. 25:55;

1 Ниф. 21:3–8.

су Үйлчлэл.

тусын тулд тэдний үйлчлэгчид бөлгөө—

47 Мөн эдүгээ, Бага Иосеф Смитэд үнэнээр би хэлж байна— Чи зарлигуудыг сахьсангүй, мөн Их Эзэний өмнө “зэмлэгдэхээр зогсох ёстой нь шаардлагатай байна;

48 “Гэр бүл чинь наманчилж, мөн зарим зүйлүүдийг орхиж, мөн чиний хэлсэн зүйлүүдэд илүү хичээнгүйлэн анхаарал тавих ёстой нь шаардлагатай байна, эсвээс тэдгээр нь байрнаасаа хөдөлгөгдөх болно.

49 Би нэгд хэлсэнээ би бүгдэд хэлдэг; ёс бус нэгэн чиний дотор хүчтэй байхгүйн тулд, мөн чамайг байрнаас чинь хөдөлгөхгүйн тулд, ямагт “залбирагтун.

50 Миний үйлчлэгч, тэрчлэн миний сүмийн бишоп Ньюел К.Витней, гэсгээн цээрлүүлэгдэж, мөн гэр бүлээ цэгцлэх шаардлагатай байна, мөн тэд гэр орондоо илүү хичээнгүй байж мөн санаа зовж байхыг мэдэгтүн, мөн ямагт залбирагтун, эсвээс тэд “байрнаасаа хөдөлгөгдөх болно.

51 Эдүгээ, би та нарт хэлж байна, найз нар минь, миний үйлчлэгч Сидней Ригдон аян замдаа гараг, мөн яараг, мөн би түүнд ярих хүчийг өгөх үед авралын сайн мэдээг мөн үгийг тэрчлэн Их Эзэний “хүлээн зөвшөөрч болохуйц жил тунхаглаг; мөн итгэлээр, нэг саналаар хийх та нарын залбирлаар би түүнийг дэмжих болно.

52 Мөн миний үйлчлэгчид, Бага Иосеф Смит, мөн Фредерик Г.Виллямс нар тэрчлэн яараг, бүр итгэлийн залбирлын дагуу энэ нь тэдэнд өгөгдөх болно; мөн та нар миний айлдваруудыг сахихын хэрээр та нар энэ дэлхийд, бас ирэх дэлхийд ч устгагдах нь үгүй.

53 Мөн, үнэнээр би та нарт хэлнэ, түүхийн, мөн улс орнуудын, мөн хаант улсуудын, мөн Бурханы хийгээд хүмүүний хуулиудын тухай “мэдлэгийг мөн Сионы авралын тулд энэ бүгдийг “олж авахын тулд, судруудыг минь “орчуулахад чи яаравчлах ёстой нь миний таалал билээ. Амен.

ХЭСЭГ 94

1833 оны тавдугаар сарын 6-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:346–347). Хайрум Смит, Ренолдс Кахун, мөн Жаред Картер нар Сүмийн барилгын хороо болж томилогдов.

47а С ба Г 95:1–2.

су Зэмлэх, Зэмлэл.

48а су Гэр бүл—

Хүүхдийн

хариуцлагууд.

49а 3 Ниф. 18:15–21.

50а С ба Г 64:40.

51а Лук 4:19.

53а су Мэдлэг.

б С ба Г 88:76–80, 118.

в су Иосеф Смитийн

Орчуулга (ИСО).

1–9, Ерөнхийлөгчийн Зөвлөлийн ажлын тулд байшин барихтай холбогдсон зарлигийг Их Эзэн өгчээ; 10–12, Хэвлэлийн газар баригдах ёстой; 13–17, Тодорхой зарим өв тогтоогдов.

МӨН дахин, үнэнээр би та нарт хэлнэ, “найз нар минь, энд Көртландын газар нутагт миний өргөөний эхлэлд, Сионы ^бгадасны хотын эхлэл мөн суурийг тавих мөн бэлтгэх ажлыг та нар эхлэх ёстой хэмээх зарлигийг би та нарт өгч байна.

2 Мөн болгоогтун, энэ нь та нарт миний өгсөн “загварын дагуу хийгдэх ёстой.

3 Мөн өмнөд дэх эхний хэсэг газар нь илчлэлтийг олж авахад мөн сүм хийгээд хаант улсад хамаарах бүх зүйлд “ерөнхийлөгчийн зөвлөлийн тохинууллын ажлын тулд, ерөнхийлөгчийн зөвлөлийн ажлын тулд ерөнхийлөгчийн зөвлөлийн байрыг барихын тулд надад ариулан адислагдаг.

4 Үнэнээр би та нарт хэлж байна, энэ нь өргөнөөрөө мөн уртаараа, дотор талын танхим нь тавин тав, жаран таван фут баригдах ёстой.

5 Мөн үүнээс хойш та нарт өгөгдөх загварын дагуу доод танхим мөн дээд танхим байх ёстой.

6 Мөн санваарын ариун жаягийн дагуу, үүнээс хойш

та нарт өгөгдөх загварын дагуу энэ нь сууринаасаа эхлэн Их Эзэнд онцгойлон адислагдах ёстой.

7 Мөн энэ нь ерөнхийлөгчийн зөвлөлийн ажлын тулд Их Эзэнд бүхэлдээ онцгойлон адислагдах ёстой.

8 Мөн аливаа “цэвэр ариун биш зүйл үүний дотор орж ирэхийг та нар тэвчихгүй байх ёстой; мөн миний ^балдар суу тэнд байх ёстой, мөн миний оршихуй тэнд байх ёстой.

9 Харин хэрэв тэнд аливаа “цэвэр ариун биш зүйл орж ирэх аваас, миний алдар суу тэнд байхгүй байх болно; мөн миний оршихуй үүнд орж ирэхгүй байх болно.

10 Мөн дахин үнэнээр би та нарт хэлье, өмнөд дэх хоёр дахь хэсэг газар нь надад зориулсан өргөө барихын тулд, миний судруудын “орчуулгын ^бхэвлэх ажлыг, мөн та нарт миний зарлиглах бүх зүйл юуг ч гэсэн хэвлэх ажлын тулд надад онцгойлон адислагдах ёстой.

11 Мөн энэ нь өргөнөөрөө мөн уртаараа тавин тав, жаран таван фут дотоод танхимтай баригдах ёстой; мөн доод болон дээд танхим тэнд байх ёстой.

12 Мөн энэ өргөө, хэвлэлийн ажлын тулд, та нарт миний зарлиглах бүх зүйл юуг ч гэсэн, бүх зүйлд, энэ нь та

94 1a С ба Г 93:45.

б су Гадас.

2a С ба Г 52:14–15.

3a С ба Г 107:9, 22.

8a Лук 19:45–46;

С ба Г 109:16–20.

б Хаад, дээд 8:10–11.

су Алдар суу.

9a С ба Г 97:15–17.

10a су Иосеф Смитийн Орчуулга (ИСО).

б С ба Г 104:58–59.

нарт өгөгдөх загварын дагуу ариун, бузарлагдахгүй байж, сууринаасаа эхлэн бүхэлдээ Их Эзэнд онцгойлон адислагдах ёстой.

13 Мөн гурав дахь хэсэг газрыг миний үйлчлэгч Хайрум Смит өөрийн өв болгон хүлээж авах болно.

14 Мөн умард дахь эхний болон хоёр дахь газруудыг миний үйлчлэгчид Ренолдс Кахун мөн Жаред Картер өөрсдийн өв болгон хүлээн авах болно —

15 Та нарт Их Эзэн миний өгсөн зарлигийн дагуу миний өргөөнүүдийг барих хороо байж, тэдэнд миний томилсон ажлыг тэд хийж болохын тулд буюу.

16 Эдгээр хоёр өргөө нь тэдгээрийн талаар би та нарт зарлиг өгөх хүртэл баригдах ёсгүй болой.

17 Мөн эдүгээ энэ цагт би үүнээс илүүг та нарт өгөх нь үгүй. Амен.

ХЭСЭГ 95

1833 оны зургадугаар сарын 1-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:350–352). Энэхүү илчлэлт нь шүтээний хийгээд зааврын тулд байрууд, ялангуяа Их Эзэний өргөө барих бурханлиг удирдамжуудын үргэлжлэл бөлгөө (хэсэг 88:119–136 мөн хэсэг 94-ийг үз).

1–6, Их Эзэний өргөө барихад бүтэлгүйтсэнийхээ учир Гэгээнтнүүд зэмлэгдэв; 7–10, Их Эзэн тэнгэрийн хүчээр өөрийн хүмүүст хишиг хүртээхийн тулд өөрийн өргөөг ашиглахыг хүсдэг; 11–17, Уг байр нь шүтээний байр болон Төлөөлөгчдийн сургуулийн тулд онцгойлон адислагдах ёстой бөлгөө.

ӨӨРИЙН хайрладаг та нарт, мөн та нарын нүглүүд “өршөөгдөхийн тулд өөрийн хайрладаг та нарыг би тэрчлэн ⁶гэсгээн цээр-

лүүлнэ гэдгийг та нарт Их Эзэн үнэнээр ийн хэлдэг, учир нь би цээрлүүлээрээ бүх зүйл дэх ⁶уруу таталтаас тэднийг ⁷чөлөөлөх замыг бэлтгэдэг авай, мөн би та нарт хайртай болой —

2 Иймийн тул, та нар миний нүүрний өмнө гэсгээн цээрлүүлэгдэх ёстой нь, мөн зэмлэгдэхээр зогсох нь шаардлагатай байна;

3 Учир нь миний “өргөөг барих талаар та нарт миний өгсөн агуу зарлигийг та нар бүх зүйлд анхаарч үзсэнгүй,

95 1a су Уучлах.
б Дэд хууль 11:1–8;
Сур. үгс 13:18;
Евр. 12:5–11;
Хил. 15:3;

С ба Г 101:4–5; 105:6.
су Зэмлэх, Зэмлэл.
в су Уруу татах,
Уруу таталт.
г 1 Кор. 10:13.

3a Хар. 1:7–11;
С ба Г 88:119.
су Ариун Сүм, Их
Эзэний Өргөө.

нэн гашуудалтай нүглийг та нар миний эсрэг үйлдлээ;

4 Бибээр өөрийн “ер бусын үйлийг тохиолгож болохын тулд, бибээр Сүнсээ бүх махан бодь дээр ^бюүлж болохын тулд, бибээр өөрийн төлөөлөгчдийг талбайгаа сүүлчийн удаа ^атайрахад бэлтгэхээр төлөвлөж байна.

5 Гэвч болгоогтун, үнэнээр би та нарт хэлж байна, томилогдсон нь та нарын дунд олон буй, тэднийг би дуудсан боловч тэднээс хэдхэн нь “сонгогдсон бөлгөө.

6 Сонгогдоогүй тэд үд дундад “харанхуйд алхлан, нэн гашуудалтай нүгэл үйлдлээ.

7 Мөн энэхүү шалтгааны учир та нарын “мацгууд хийгээд та нарын гашуудал, хөрвүүлсэн утгаар бол, эхний өдрийг ^ббүтээгч эхлэл ба төгсгөл болох “Сабаотын Их Эзэний чихэнд ирж болохын тулд та нар өөрсдийн ‘онцгой ариун хуралдайг дуудах ёстой хэмээх зарлигийг би та нарт өгч байна.

8 Тийм ээ, үнэнээр би та нарт хэлнэ, тэнгэрийн хүчээр миний сонгосон тэдэнд “хишиг хүртээхээр миний төлөвлөж буй байрыг та нар

барих ёстой хэмээх зарлигийг би та нарт өгсөн билээ;

9 Учир нь энэ бол Эцэгээс та нарт өгсөн “амлалт билээ; тиймийн тул, бүр Иерусалим дахь миний төлөөлөгчдийн адилаар, түр үлдэхийг би та нарт зарлиглаж байна.

10 Гэсэн хэдий ч, миний үйлчлэгчид нэн гашуудалтай нүгэл үйлдлээ; бошиглогчдын “сургуульд ^бзөрчилдөөн бий болжээ: энэ нь надад нэн гашуудалтай байлаа хэмээн Их Эзэн чинь хэлж байна; тиймийн тул, би тэднийг гэсгээн цээрлүүлэгдэхээр урагш илгээв.

11 Үнэнээр би та нарт хэлнэ, та нар өргөө барих ёстой нь миний таалал болой. Хэрэв та нар миний зарлигуудыг сахих аваас, үүнийг барих хүч та нарт байх болно.

12 Хэрэв та нар миний зарлигуудыг эс “сахих аваас, Эцэгийн ^бхайр та нар дээр цаашид үл үргэлжилнэ, тиймийн тул та нар харанхуйд алхах болно.

13 Эдүгээ энэ нь мэргэн ухаан, мөн Их Эзэний оюун буюу—өргөө дэлхийн маягаар биш баригдаг, учир нь

4а Иса. 28:21;
С ба Г 101:95.

б Сур. үгс 1:23;
Иоел 2:28;
С ба Г 19:38.
су Сүнсний
бэлгүүд; Ариун
Сүнс.

в Иаков 5:61–75;
С ба Г 24:19; 33:3–4.
су Их Эзэний
талбай.

5а Мат. 20:16;
С ба Г 105:35–37;
121:34–40.
су Сонгогдогсод.

6а су Сүнсний
харанхуй.

7а су Мацаг барих,
Мацаг барилт.
б су Бүтээх, Бүтээл.
в су Иехова.
г С ба Г 88:70,
74–82, 117–120.

8а С ба Г 38:32;
39:15; 43:16;
110:9–10.
су Хишиг
(индаумент).

9а Лук 24:49.
10а су Бошиглогчдын
сургууль.
б су Уруу таталт.
12а Иохан 15:10.
б 1 Иохан 2:10, 15.

дэлхийн маягаар амьдрахыг би та нарт өгөөгүй бөлгөө;

14 Тиймийн тул, энэхүү хүчинд та нарын тохоож мөн томилсон та нарын гуравт нь миний үзүүлэх маягаар энэ нь баригдаг.

15 Мөн үүний хэмжээ нь өргөнөөрөө тавин таван фут байх ёстой, мөн энэ нь уртаараа жаран таван фут, үүний дотор талын танхим байг.

16 Мөн дотор танхимын доод хэсэг нь та нарын ариун ёслолын өргөл мөн та нар номлохын, мөн та нар мацаг

барихын, мөн та нар залбирахын, мөн та нар хамгийн ариун нандин хүслүүдэд надад “өргөхийн тулд надад онцгойлон адислагдаг хэмээн та нарын Их Эзэн хэлж байна.

17 Дотор танхимын дээд хэсэг нь миний төлөөлөгчдийн сургуулийн тулд надад онцгойлон адислагдаг хэмээн “Аманы Хүү; эсвээс, өөрөөр хэлбэл, Алфус; эсвээс, өөрөөр хэлбэл, Омегус; бүр та нарын “Их Эзэн Есүс Христ хэлж байна. Амен.

ХЭСЭГ 96

1833 оны зургадугаар сарын 4-нд Огайогийн Көртланд дахь Сионы хот буюу гадасны дэг журмыг Көртланд дахь Гэгээнтнүүдэд үлгэр жишээ болгон үзүүлж, Бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:352–353). Уг үйл явдал нь дээд санваартнуудын чуулган байсан бөгөөд хэлэлцсэн үндсэн гол асуудал нь Көртландын ойролцоо Сүмийн эзэмшдэг байсан Френчийн ферм хэмээгддэг байсан хэсэг газрыг зарах явдал байв. Фермийн үнийг хэн хариуцах ёстой талаар чуулган санал нэгдэж чадаагүй учраас уг асуудлын талаар Их Эзэнээс асуухаар бүгд санал нэгдэв.

1, Сионы Көртланд Гадас хүчтэй болгогдох ёстой; 2–5, Бишоп Гэгээнтнүүдэд зориулан өвүүдийг хуваах ёстой; 6–9, Жон Жонсон нэгдсэн журмын гишүүн байх ёстой.

БОЛГООГТУН, би та нарт хэлж байна, энэ асуудлын талаар та нар хэрхэн үйлдэхийг мэдэж болох нь мэргэн ухаан болой, учир нь Сионы хүчирхэгжилтийн тулд миний

үндэслэсэн энэ “гадас хүчтэй болгогдох ёстой нь надад шаардлагатай байна.

2 Тиймийн тул, өөрийн ариун өргөөг дээр нь барихаар миний төлөвлөж буй, та нарын дунд нэрлэгдсэн тэр газрын үнийг миний үйлчлэгч Ньюел К.Витней хариуцаг.

3 Мөн дахин, мэргэн ухааны дагуу, өвүүдийг эрэлхийлж буй тэдний ашиг тусын тулд,

энэ нь та нарын дундах зөвлөлд тодорхойлогдохын дагуу хэсэг газруудад хуваагдаг.

4 Тиймийн тул, та нар энэ асуудлыг мөн миний “журамд шаардагдах хувийг авч үзэн миний үгийг хүмүүний үрст урагш авчрах зорилгын төлөө байхад мэдэгтүн.

5 Учрыг болгоогтун, үнэнээр би та нарт хэлнэ, хүмүүний үрсийн зүрх сэтгэлийг та нарын сайн сайхны төлөө захируулах зорилгын тулд миний үг хүмүүний үрст урагш одох ёстой нь надад нэн шаардлагатай байна. Бүр тийм буюу. Амен.

6 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, энэ нь мэргэн ухаан бөгөөд надад шаардлагатай болой, өргөлийг нь би хүлээн авсан, мөн залбирлыг нь би сонссон, энэ

цагаас хойш зарлигуудыг минь сахихын хэрээр мөнх амьдралын амлалтыг түүнд би өгсөн миний үйлчлэгч Жон Жонсон—

7 Учир нь тэрээр “Иосефын удам мөн түүний эцгүүдэд хийгдсэн адислалуудыг хүртэгч билээ—

8 Үнэнээр би та нарт хэлж байна, тэрээр миний үгийг хүмүүний үрст урагш авчрахад тусалж болохын тулд тэрээр уг журмын гишүүн байх ёстой нь надад шаардлагатай байна.

9 Тиймийн тул, та нар түүнийг энэ адислалд томилох ёстой, тэрээр тэнд амьдарч болохын тулд мөн та нарын дунд нэрлэгдсэн өргөөний барьцааг тэрээр хичээнгүйлэн эрэлхийлэх ёстой. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 97

1833 оны наймдугаар сарын 2-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:400–402). Энэхүү илчлэлт нь ялангуяа Миссурийн Жаксон гүнлэгийн Сион дахь Гэгээнтнүүдийн ажил хэрэгтэй холбогдсон мэдээлэл хүсч Бошиглогч Их Эзэнээс асуусны хариу байлаа. Миссури дэх Сүмийн гишүүд энэ үед ноцтой хавчлагад өртөж, тийнхүү 1833 оны долдугаар сарын 23-нд Жаксон гүнлэгийг орхин явах тухай гэрээнд гарын үсэг зурахаар албадуулжээ.

1–2, Сион дахь (Миссури, Жаксон гүнлэг) Гэгээнтнүүдээс олон нь итгэлтэй байдлынхаа төлөө адислагдав; 3–5, Парлей П.Пратт Сион дахь сургуульд хөдөлмөрлөснийхөө төлөө магтуулав; 6–9, Гэрээгээ дагадаг

тэд Их Эзэнээр хүлээн зөвшөөрөгддөг; 10–17, Зүрх сэтгэлдээ цэвэр ариун тэд дотор нь Бурханыг харах өргөө Сионд баригдах ёстой; 18–21, Сион бол зүрх сэтгэлдээ цэвэр ариун тэд юм; 22–28, Хэрэв итгэлтэй

байх аваас, Сион Их Эзэний цээрлүүлэлтээс зугтах болно.

Үнэнээр би та нарт хэлж байна, найз нар минь, тэднээс олон нь үнэхээр даруу байж мөн мэргэн ухаанд суралцахын тулд мөн үнэнийг олохын тулд хичээнгүйлэн эрэлхийлж буй, “Сионы нутаг дахь ах дүүсийн тань талаарх өөрийн тааллыг бибээр та нарт харуулахын тулд бибээр та нарт өөрийн дуу хоолойгоор, бүр Сүнснийхээ дуу хоолойгоор ярьдаг.

2 Үнэнээр, үнэнээр би та нарт хэлж байна, иймүүд нь адислагдсан болой, учир нь тэд амжилтад хүрэх болно; учир нь Их Эзэн, бибээр тэднийг би шүүлтэд авчрах үед бибээр зөвтгөгдөж болохын тулд, бүх номхон дөлгөөн хүмүүст мөн би өөрийн хүссэн бүх хүмүүст “нигүүсэл үзүүлдэг бөлгөө.

3 Болгоогтун, Сион дахь “сургуулийн талаар би та нарт хэлье, Сионд сургууль байх ёстой нь, мөн тэрчлэн миний үйлчлэгч ⁶Парлей П.Пратт Их Эзэн миний таашаалд нийцдэг, учир нь тэрбээр надад итгэлтэй хэвээр үлджээ.

4 Мөн тэрбээр надад итгэлтэй хэвээр үлдэхээ үргэлж-

лүүлэхийн хэрээр, намайг түүнд бусад зарлигуудыг өгөх хүртэл тэрбээр Сионы нутаг дахь сургуулийг тэргүүлэхээ үргэлжлүүлсээр байх болно.

5 Мөн Сион дахь сүмийг мөн сургуулийг сэнхрүүлэх бүх судрыг болон нууцуудыг тайлбарлах үй олон адисла-лаар би түүнийг адислах болно.

6 Мөн сургуульд үлдэгсдэд Их Эзэн бибээр нигүүлслийг үзүүлэхэд бэлэн байна; гэсэн хэдий ч “гэсгээн цээрлэгдэх ёстой нь шаардагдаж буй тэд тэнд буй, мөн тэдний ажлууд мэдэгдэх болно.

7 Моднуудын үндсэнд “сүх хэдийнээ зоогджээ; иймээс сайн ⁶үр жимс ургуулдаггүй аливаа мод цавчуулан, галд хаягдах болно. Их Эзэн, бибээр үүнийг ярилаа.

8 Үнэнээр би та нарт хэлье, тэдний дундах, “зүрх сэтгэл нь ⁶үнэнч шударга мөн харууссан мөн сэтгэл нь гэмшсэн гэдгийг мэддэг тэд, мөн гэрээнүүдээ ⁶золиослолоор дагахад ‘бэлэн байгаа тэд — тийм ээ, Их Эзэн миний зарлиглах золиослол бүрээр — тэд надаас ⁹хүлээн зөвшөөрөгддөг билээ.

9 Учир нь Их Эзэн, бибээр үнэт үр жимс нэн ихийг

97 1a су Сион.
2a Мат. 5:5; Мозая 3:19.
3a су Бошиглогчдын сургууль.
б су Парлей, Пратт Паркер.

6a су Зэмлэх, Зэмлэл.
7a Мат. 3:10.
б Лук 6:43–45;
Алма 5:36, 52;
3 Ниф. 14:15–20.
8a су Үнэнч, Үнэнч

шударга.
б су Харууссан зүрх.
в су Золиослол.
г С ба Г 64:34.
д С ба Г 52:15; 132:50.

ургуулдаг, цэвэрхэн горхины дэргэд сайн газарт таригддаг мод лугаа адил тэднийг урагш авчрах болгоно.

10 Үнэнээр би та нар хэлнэ, та нарт миний өгсөн “загварын дагуу Сионы газар нутагт надад ^бөргөө баригдах нь миний хүсэл зориг болой.

11 Тийм ээ, энэ нь миний хүмүүсийн аравны нэгээр түргэн баригдаг.

12 Болгоогтун, Сионы авралын төлөө надад “өргөө баригдаж болохын тулд, энэ бол Их Эзэн, бибээр тэдний гараас шаардах ^баравны нэг хийгээд золиослол болой —

13 Бүх гэгээнтнүүдийн хувьд “талархлын газар, мөн хэд хэдэн дуудлагууд хийгээд албан тушаалуудад тохиууллын ажилд дуудагддаг тэд бүгдийн зааврын газар байхын тулд юм;

14 Тэд өөрсдийн тохиуулал, онол, зарчим мөн сургаалд мөн “түлхүүрүүд нь та нарт олгогдсон дэлхий дээрх Бурханы ^бхаант улсад хамаарах бүх зүйлийн ^бойлголгод төгөлдөржихийн тулд юм.

15 Мөн Их Эзэний нэрээр надад өргөө барьж мөн энэ нь бузарлагдахгүй байхын

тулд аливаа “цэвэр ариун биш зүйлийг үүн дотор орохыг хүлцэхгүй байхын хэрээр, миний ^балдар суу үүн дээр амрах болно.

16 Тийм ээ, мөн миний “оршихуй тэнд байх болно, учир нь би үүнд ирэх болно, мөн зүрх сэтгэлээрээ ^бцэвэр ариун, үүнд ирэх тэд бүгд Бурханыг харах болно.

17 Гэвч хэрэв энэ нь бузарлагдах аваас, би үүнд орж ирэх нь үгүй, мөн миний алдар суу тэнд байх нь үгүй; учир нь ариун биш ариун сүмүүдэд бибээр орохгүй байх болно.

18 Мөн эдүгээ болгоогтун, хэрэв Сион эдгээр зүйлүүдийг хийх аваас, тэр “цэцэглэн хөгжиж мөн өөрийгөө өргөжүүлэн тэлж мөн эрхэм сайхан, туйлын агуу их мөн туйлын сүртэй болох бөлгөө.

19 Мөн дэлхийн “үндэстнүүд түүнийг хүндэтгэх болно, мөн: ^бСион бидний Бурханы хот мөн нь лавтай, мөн Сион унаж, мөн байрнаасаа хөдөлгөгдөж ч чадахгүй нь лавтай, учир нь Бурхан тэнд буй, мөн Их Эзэний гар тэнд буй хэмээн хэлэх болно.

20 Мөн тэрээр чадлынхаа

10a С ба Г 115:14–16.

б С ба Г 57:3;

88:119; 124:51.

12a су Ариун Сүм, Их Эзэний Өргөө.

б су Аравны нэг төлөх, Аравны нэг.

13a су Талархалтай, Талархах, Талархал өргөх.

14a су Санваарын түлхүүрүүд.

б су Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс.

в су Мэдлэг.

15a С ба Г 94:9; 109:20–21.

б Хар. 2:7; С ба Г 84:5.

16a С ба Г 110:1–10.

б Мат. 5:8;

С ба Г 67:10–13; 88:68.

су Цэвэр ариун, Цэвэр ариун байдал.

18a С ба Г 90:24; 100:15.

19a Иса. 60:14;

Зех. 2:10–12;

С ба Г 45:66–70; 49:10.

б су Шинэ Иерусалим.

хүчээр түүний аврал хийгээд түүний өндөр “цамхаг байхаар тангарагласан билээ.

21 Тиймийн тул, үнэнээр Их Эзэн ийн хэлж байна, Сион баясаг, учир нь энэ нь “Сион—зүрх сэтгэлдээ цэвэр ариун тэд юм; тиймийн тул, ёс бус тэд бүгд гашуудаж байхад, Сион баясаг.

22 Учрыг болгоогтун, мөн харагтун, бурханлиг бус тэдний дээр “өс хонзон хуй салхи мэт хурднаар ирдэг бөлгөө; мөн хэн үүнээс зугтаж чадах билээ?

23 Их Эзэний “гэсгээн цээрлүүлэлт шөнөөр мөн өдрөөр тохиох болно, мөн үүний мэдээ бүх хүмүүсийг шаналгах болно; тийм ээ, энэ нь Их Эзэнийг ирэх хүртэл зогсох нь үгүй;

24 Учир нь тэдний жигшүүрт хэргүүд хийгээд тэдний бүх ёс бус ажлуудын эсрэг Их Эзэний зэвүүцэл дүрэлзэж байна.

25 Гэсэн хэдий ч, түүнд миний зарлигласан бүх зүйлийг юуг ч гэсэн тэрээр хийхээ анхааралтай дагах аваас, Сион “зугтаж чадах болно.

26 Гэвч түүнд миний зарлигласан юуг ч гэсэн тэрээр дагахгүй аваас, бүх ажлуудынх нь дагуу гашуун зовлон зүдгүүрээр, “өвчнөөр, тахлаар, илдээр, ^бөс хонзонгоор, “устгагч галаар түүн дээр би ^вайлчлах болно.

27 Гэсэн хэдий ч Их Эзэн бибээр түүний өргөлийг хүлээн авсан нь түүний чихэнд зөвхөн энэ удаа уншигдаг; мөн тэр дахин нүгэл үл үйлдэх аваас, эдгээр зүйлүүдийн “аль нь ч түүн дээр ирэхгүй байх болно;

28 Мөн бибээр адислалуудаар түүнийг “адисалж, мөн адислалуудын үй олныг үүн дээр мөн түүний үеийнхэн дээр үүрд мөн мөнхөд олшруулах авай хэмээн та нарын Их Эзэн хэлдэг. Амен.

ХЭСЭГ 98

1833 оны наймдугаар сарын 6-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:403–406). Энэхүү илчлэлт Миссури дэх Гэгээнтнүүд дээрх мөрдлөг хавчлагын улмаас иржээ. Миссури дэх Гэгээнтнүүд бие бялдын хувьд хэлмэгдэн, мөн өмч хөрөнгөө алдсаны улмаас хариу болон өс хонзон авах сонирхол бий болсон нь зүй ёсны юм. Тиймийн тул, Их Эзэн энэ илчлэлтийг өгчээ. Гэсэн ч Миссури дэх асуудлуудын зарим сураг чимээ Көртланд дахь (нэг мянга дөрвөн

20а 2 Сам. 22:3.

21а Моисе 7:18.
су Цэвэр ариун,
Цэвэр ариун
байдал; Сион.

22а су Өс хонзон.

23а Иса. 28:14–19;

С ба Г 45:31.

25а 2 Ниф. 6:13–18;

С ба Г 63:34;

ИС—А 1:20.

26а Лук 21:10–13.

б Малах. 4:1–3;

3 Ниф. 21:20–21.

в Иоел 1:15–20.

г С ба Г 84:54–59.

27а Езек. 18:27.

28а су Адислах,
Адислагдах,
Адислал.

зуун дөчин километр хол) Бошиглогчид хүрсэн нь эргэлзээгүй билээ, нөхцөл байдлын хуридал нь тэр өдөр гагцхүү илчлэлтээр түүнд мэдэгдсэн байж болох юм.

1–3, Гэгээнтнүүдийн зовлон зүдгүүрүүд тэдний сайн сайхны тулд байх болно; 4–8, Гэгээнтнүүд уг нутгийн үндсэн хуулийн анд нөхөд байх ёстой; 9–10, Үнэнч шударга, ухаалаг мөн сайн хүмүүс төр, засгийн газрын тулд дэмжигддэг байх ёстой; 11–15, Их Эзэний зорилгын тулд амиа зориулдаг тэд мөнх амьдралыг авах болно; 16–18, Дайнаас татгалзаж, мөн энх тайвныг тунхагла; 19–22, Көртланд дахь Гэгээнтнүүд ээмлэгдэж мөн наманчлахаар зарлигдуулав; 23–32, Их Эзэн өөрийн хүмүүс дээр тохоогдсон мөрдлөг хавчлагууд хийгээд зовлон зүдгүүрүүдийг зохицуулах хуулиудыг илчлэв; 33–38, Их Эзэн зарлигласан үед л дайн зөвхөн зөвтгөгддөг; 39–48, Гэгээнтнүүд дайснаудаа өршөөх ёстой, хэрэв тэд наманчлах аваас, Их Эзэний өшөө авалтаас тэгвэл зугтах болно.

ҮНЭНЭЭР би та нарт хэлж байна, найз нар минь, бүү “эмээгтүн, зүрх сэтгэл чинь тайтгаруулагдаг; тийм ээ, үргэлж баясагтун, мөн юм бүхэнд ^бталархал илэрхийлж бай;

2 Их Эзэнээс тэвчээртэй “хүлээ, учир нь залбирлууд чинь Сабаотын Их Эзэний

сонорт ирсэн болой, мөн энэхүү лац хийгээд гэрээний хамт цэдэглэгдсэн авай — тэдгээр нь соёрхогдохоор Их Эзэн андгайлж мөн тогтоосон билээ.

3 Тиймийн тул, тэдгээр нь биелэгдэх болно хэмээх энэ амлалтыг өөрчлөгдөшгүй гэрээний хамт тэрээр та нарт өгч байна; мөн та нарын “зовж зүдэрсэн бүх зүйл мөн миний нэрний алдар суутай нийлээд та нарын сайн сайхны төлөө ажиллах болно хэмээн Их Эзэн хэлж байна.

4 Мөн эдүгээ, уг нутгийн хуулиудын талаар үнэнээр би та нарт хэлье, бибээр тэдэнд юуг ч зарлиглалаа гэсэн, миний хүмүүс бүх зүйлийг хийхээ анхааралтай дагах ёстой нь миний таалал юм.

5 Эрх, онцгой боломжуудыг хадгалснаар эрх чөлөөний зарчмыг хөхүүлэн дэмжигч “үндсэн хуулийн шинжтэй уг нутгийн ^бхууль нь бүх хүн төрөлхтөнд хамаатай мөн миний өмнө зөв бөлгөө.

6 Тиймийн тул, Их Эзэн бибээр та нарыг мөн өөрийн сүмийн та нарын ах дүүсийг үндсэн хууль болох уг нутгийн хуульд нөхөрсгөөр хандахыг зөвтгөх авай;

98 1a С ба Г 68:6.

б су Талархалтай,
Талархах, Талархал
өргөх.

2a Дуул. 27:14;

Иса. 30:18–19;

С ба Г 133:45.

3a С ба Г 122:7.

су Дайсан.

5a С ба Г 101:77–80;

109:54.

су Үндсэн хууль;
Эрх чөлөө.

б 1 Петр 2:13–14;

С ба Г 58:21; 134:5.

7 Мөн хүмүүний хуульд хамаатай үүнээс илүү буюу дутуу юу ч гэсэн чөтгөрөөс ирдэг бөлгөө.

8 Их Эзэн, бибээр та нарыг “чөлөөтэй болгодог, тиймийн тул, та нар үнэхээр эрх чөлөөтэй билээ; мөн хууль ч тэрчлэн та нарыг эрх чөлөөтэй болгодог.

9 Гэсэн хэдий ч, “ёс бусчууд удирдахад хүмүүс гашууддаг буюу.

10 Иймийн тул, “үнэнч шударга хүмүүс мөн ухаалаг хүмүүс хичээнгүйлэн эрэлхийлэгддэг байх ёстой, мөн сайн хүмүүс мөн ухаалаг хүмүүсийг та нар дэмжихийг анхааралтай дагах ёстой; эс тэгвээс эдгээрээс дутуу юу ч гэсэн чөтгөрөөс ирдэг бөлгөө.

11 Мөн та нар хилэнцэт бүхнийг орхиж, мөн сайн бүхэнтэй нэгдэн нийлэх ёстой, та нар Бурханы амнаас урагш гарах “үг бүрээр амьдрах ёстой хэмээх зарлигийг би та нарт өгч байна.

12 Учир нь тэрээр итгэлтнүүдэд шат шатаар, дүрэм дүрмээр “өгөх болно; мөн би та нарыг ^бсорьж мөн үүгээр та нарыг нотлох болно.

13 Мөн миний зарчимд

миний нэрийн төлөө, амиа “зориулдаг хэн ч болов үүнийг дахин олж авах болно, бүр мөнх амьдралыг бөлгөө.

14 Тиймийн тул, дайснуудаасаа бүү “ай, учир нь та нар зохистойгоор олдож болохын тулд би та нарыг миний гэрээнд үлдэх нь үү үгүй юу гэдгийг бүр ^бүхэлд бүх зүйлд “нотлох болно гэдгийг зүрх сэтгэлдээ тогтоосон билээ хэмээн Их Эзэн хэлж байна.

15 Учир нь хэрэв та нар миний гэрээнд үл үлдэх аваас, та нар надад зохистой бус болой.

16 Тиймийн тул, “дайнаас ^бтатгалзаж “энх тайвныг тунхагла, мөн хүүхдүүдийн зүрх сэтгэлийг эцгүүд уруу нь, эцгүүдийнх нь зүрх сэтгэлийг хүүхдүүд уруу нь ‘эргүүлэхийг хичээнгүйлэн эрэлхийл;

17 Мөн дахин, бибээр ирж бүхэл дэлхийг зүхлээр арчин, мөн бүх маханбодь миний өмнө шатахгүйн тулд “иудейчүүдийн зүрх сэтгэлийг бошиглогчид уруу, мөн бошиглогчдыг иудейчүүд уруу буюу;

18 Зүрх сэтгэл чинь бүү тэвдэн сандраг; учир нь миний Эцэгийн өргөөнд “олон харш буй, мөн та нарт би байрыг

8a Иохан 8:32;
2 Кор. 3:17.
су Сонгох эрх;
Эрх чөлөө, Эрх чөлөөт байдал.
9a Сур. үгс 29:2.
10a су Үнэнч, Үнэнч шударга.
11a Дэд хууль 8:3;
Мат. 4:4;
С ба Г 84:43-44.
12a Иса. 28:10;

С ба Г 42:61.
б Абр. 3:25-26.
13a Лук 9:24;
С ба Г 101:35-38;
103:27-28.
су Санаатайгаар алах, Санаатай аллага.
14a Нех. 4:14;
С ба Г 122:9.
б Илч. 2:10;
С ба Г 136:31, 39.

в С ба Г 124:55.
16a су Дайн.
б Алма 48:14.
су Амар амгаланг тогтоогч.
в су Амар амгалан.
г Малах. 4:5-6;
С ба Г 2:1-2.
17a су Иудейчүүд.
18a Иохан 14:2;
С ба Г 59:2;
76:111; 81:6.

бэлтгэсэн билээ; миний Эцэг болон миний байгаа тэнд та нар ч тэрчлэн байх болно.

19 Болгоогтун, Көртланд дахь сүмд байгаа олон нь Их Эзэн миний таашаалд үл нийцдэг болой;

20 Учир нь тэд нүглүүдээ, мөн ёс бус замуудаа, зүрх сэтгэлийнхээ бардамналыг, мөн шунахай сэтгэлээ, мөн өөрсдийн бүхий л зэвүүн зүйлүүдийг орхихгүй, мөн тэдэнд миний өгсөн мэргэн ухааны үгс хийгээд мөнх амьдралд анхаарал тавихгүй байна.

21 Үнэнээр би та нарт хэлдэг, хэрэв тэд наманчлахгүй мөн тэдэнд миний хэлсэн бүх зүйлийг анхааралтай дагахгүй аваас, Их Эзэн бибээр тэднийг “гэсгээн цээрлүүлж мөн хүссэнээ юуг ч болов хийх болно.

22 Мөн дахин би та нарт хэлж байна, та нарт миний зарлигласан юуг ч болов та нар “анхааралтай дагах аваас Их Эзэн бибээр бүх хилэгнэл мөн зэвүүцлийг та нараас эргүүлэх болно, мөн тамын ʼүүд та нарыг дийлэх нь үгүй.

23 Эдүгээ би гэр бүлүүдийн чинь талаар та нарт ярьж— хэрэв хүмүүс та нарыг, эсвээс гэр бүлүүдийг чинь нэг удаа “цохих аваас, мөн та нар үүнийг хүлээцтэйгээр тэвч,

мөн тэдний эсрэг бүү зүх, мөн өс хонзон бүү эрэлхийл, та нар шагнагдах болно.

24 Харин хэрэв та нар үүнийг хүлээцтэйгээр үл тэвчих аваас, өөрсдөд чинь байх ёстой шударга хэмжүүрээр “хэмжигдсэнд та нар тооцогдох болно.

25 Мөн дахин, хэрэв дайсан чинь та нарыг хоёр дахь удаагаа цохих аваас, мөн та нар дайсныхаа эсрэг бүү зүх, мөн үүнийг хүлээцтэйгээр тэвч, шагнал чинь зуу дахин их байх болно.

26 Мөн дахин, хэрэв тэрээр та нарыг гурав дахь удаагаа цохих аваас, мөн та нар үүнийг “хүлээцтэйгээр тэвч, шагнал чинь та нарт давхарлаж, дөрөв дахин нэмэгдэх болно.

27 Мөн хэрэв тэрээр эс наманчлах аваас эдгээр гурван гэрчлэл дайсны чинь эсрэг зогсож, мөн арилгагдах нь үгүй.

28 Мөн эдүгээ, үнэнээр би та нарт хэлж байна, хэрэв тэр дайсан миний өс хонзонгоос зайлнаар, миний өмнө шүүлтэнд авчрагддаггүй юм бол, тэгээд тэрээр дахин та нар дээр мөн та нарын гэр бүлүүд дээр, бүр хүүхдүүдийн чинь хүүхдүүдэд гурав дахь мөн дөрөв дэх үеийнхэнд чинь ирэхгүйн тулд, та

21a Мозая 23:21;

Хил. 12:3.

су Зэмлэх, Зэмлэл.

22a су Дуулгавартай байх, Дуулгавар-

тай, Дуулгавартай дагах.

б Мат. 16:17–18;

С ба Г 33:12–13.

23a Лук 6:29;

Алма 43:46–47.

су Хавчих,

Хавчлага.

24a Мат. 7:1–2.

26a су Тэвчээр.

нар миний нэрээр “сэрэмжлүүлэхийг мэдэгтүн.

29 Мөн тэгээд, хэрэв тэрээр та нар дээр, эсвээс та нарын хүүхдүүд дээр, эсвээс та нарын хүүхдүүдийн хүүхдүүд дээр гурав дахь мөн дөрөв дэх үеийнхэнд чинь ирэх аваас, бибээр дайсныг чинь гарт чинь оруулна;

30 Мөн тэгээд хэрэв чи түүнийг хэлтрүүлэх аваас, зөв шударга байдлынхаа учир чи шагнагдах болно; мөн тэрчлэн хүүхдүүд чинь мөн хүүхдүүдийн чинь хүүхдүүд гурав дахь мөн дөрөв дэх үедээ ч адил болой.

31 Гэсэн хэдий ч, дайсан чинь гарт чинь байна; мөн хэрэв чи түүнд ажлуудынх нь дагуу хариуг нь өгөх аваас, чи зөвтгөгдөх болой; хэрэв тэрээр амийг чинь эрэлхийлсэн бол мөн амь нас чинь түүгээр аюулд учирсан бол, дайсан чинь гарт чинь байж, мөн чи зөвтгөгдөх болой.

32 Болгоогтун, энэ бол би өөрийн үйлчлэгч Нифайд мөн чиний “эцгүүд Иосеф мөн Иаков мөн Исаак, мөн Абрахам, мөн эртний бүх бошиглогч хийгээд төлөөлөгчиддөө өгсөн хууль билээ.

33 Мөн дахин, энэ бол Их Эзэн бибээр тэдэнд зарлигласнаас бусдаар тэд аливаа үндэстэн, ястан, хэлтэн буюу хүмүүсийн эсрэг тулалдахаар явах ёсгүй хэмээн эрт дээр

үеийнхэндээ өгсөн “хууль бөлгөө.

34 Мөн аливаа үндэстэн, хэлтэн буюу хүмүүс тэдний эсрэг дайн зарлах аваас, тэд эхлээд тэрхүү хүмүүс, үндэстэн буюу хэлтэнд “энх тайвны тугийг өргөх ёстой;

35 Мөн хэрэв тэрхүү хүмүүс энх тайвны саналыг үл хүлээн авсан бол, мөн хоёр дахь болон гурав дахь удаад ч адил бол, тэд эдгээр гэрчлэлүүдийг Их Эзэний өмнө авчрах ёстой;

36 Тэгвэл Их Эзэн бибээр тэдэнд зарлиг өгч, мөн тэрхүү үндэстэн, хэлтэн буюу хүмүүсийн эсрэг дайтахаар явахад нь тэднийг зөвтгөх болно.

37 Мөн Их Эзэн, бибээр тэдний тулалдаануудад, мөн тэдний хүүхдүүдийн тулалдаануудад, тэдний хүүхдүүдийн хүүхдүүдийнхэд ч мөн адил, гурав дахь мөн дөрөв дэх үедээ тэд бүх дайснаасаа өөрсдийнхөө төлөө өс хонзонгоо авах хүртэл “байлдах болно.

38 Болгоогтун, энэ нь миний өмнөх зөвтгөлийн тулд бүх хүмүүст үлгэр жишээ болой хэмээн та нарын Бурхан, Их Эзэн хэлдэг.

39 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлье, дайсан чинь та нар дээр анх удаа ирсний дараа тэрээр наманчилж мөн чамд өршөөлийг залбиран ирэх аваас, чи түүнийг уучлах ёстой, мөн үүнийг дайсныхаа

28a су Сэрэмжлэх,
Сэрэмжлүүлэг.
32a С ба Г 27:10.

33a Дэд хууль 20:10;
Алма 48:14–16.
34a С ба Г 105:38–41.

37a Иош. 23:10;
Иса. 49:25.

эсрэг гэрчлэл болгон дахин өргөх ёсгүй—

40 Мөн энэчлэн хоёр дахь мөн гурав дахь удаад буюу; мөн дайсан чинь та нарын эсрэг үйлдсэн зөрчлөө наманчлахын тоогоор, чи түүнийг далан долоон удаа хүртэл “уучлах ёстой.

41 Мөн хэрэв тэрээр чиний эсрэг зөрчлийг анх удаа үйлдээд үл наманчиллаа ч гэсэн, чи түүнийг уучлах ёстой.

42 Мөн хэрэв тэрээр чиний эсрэг зөрчлийг хоёр дахь удаагаа үйлдээд, мөн үл наманчиллаа ч гэсэн, чи түүнийг уучлах ёстой.

43 Мөн хэрэв тэрээр чиний эсрэг зөрчлийг гурав дахь удаагаа үйлдээд, мөн үл наманчлах аваас, чи тэрчлэн түүнийг уучлах ёстой.

44 Гэвч хэрэв тэрээр чиний эсрэг гэм бурууг дөрөв дэх удаагаа үйлдэх аваас, чи түүнийг уучлах ёсгүй, харин эдгээр гэрчлэлүүдийг Их Эзэний өмнө авчрах ёстой; мөн тэдгээр нь түүнийг наманчлах хүртэл арилгагдахгүй, мөн чиний эсрэг түүний үйлдсэн бүх зүйлд хариу

чинь дөрөв дахин нэмэгдэх болно.

45 Мөн хэрэв тэрээр үүнийг хийх аваас, чи бүхий л зүрх сэтгэлээрээ түүнийг уучлах ёстой; мөн хэрэв тэрээр үүнийг үл хийх аваас, Их Эзэн бибээр дайснаас чинь чиний төлөө “өс хонзонг зуу дахин ихээр авах болно;

46 Мөн түүний хүүхдүүд дээр мөн намайг үзэн яддаг түүний хүүхдүүдийн хүүхдүүд, тэд бүгд дээр, “гурав дахь мөн дөрөв дэх үеийнхэн дээр нь буюу.

47 Гэвч хүүхдүүд нь, эсвээс хүүхдүүдийнх нь хүүхдүүд наманчилж, мөн бүхий л зүрх сэтгэл мөн бүх хүчин чадал, оюун, мөн чадлаараа өөрсдийн Бурхан Их Эзэнд “эргэж, мөн өөрсдийн эсвээс эцгүүдийнхээ эцгүүдийн үйлдсэн зөрчлийн төлөө дөрөв дахин сэргээх аваас, тэгэхэд чиний зэвүүцэл арилах ёстой;

48 Мөн “өс хонзон дахин тэдэн дээр ирэх нь үгүй, мөн тэдний зөрчил тэдний эсрэг гэрчлэл болон Их Эзэний өмнө дахиад хэзээ ч авчрагдахгүй байх болно. Амен.

ХЭСЭГ 99

1832 оны наймдугаар сард Огайогийн Хайрамд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Жон Мурдокт өгөгдсөн илчлэлт оршвой. 1876 оноос эхлэн Сургаал ба Гэрээний хэвлэлүүд энэ илчлэлтийг Көртланд, 1833 оны наймдугаар сар хэмээн жагсаалтад оруулсан

40a Мат. 18:21–22;
С ба Г 64:9–11.
су Уучлах.

45a Морм. 8:20.
46a Дэд хууль 5:9–10.
47a Мозая 7:33;

Морм. 9:6.
48a Езек. 18:19–23.

байдаг хэдий ч, өмнөх хэвлэлүүд болон түүхийн бусад цэдгүүд зөв мэдээллийг нотолж байгаа болно.

1–8, Жон Мурдок сайн мэдээг тунхаглахаар дуудагдав, мөн түүнийг хүлээн авдаг тэд Их Эзэнийг хүлээн авч мөн нигүүлслийг олж авах болно.

БОЛГООГТУН, миний Бүйлчлэгч Жон Мурдок, чи айлаас айлд, тосгоноос тосгонд, мөн хотоос хотод тэдгээрийн оршин суугчдад миний үүрдийн сайн мэдээг тунхаглахаар дорнод мужуудад “хавчлага хийгээд харанхуйд явахаар дуудагдлаа хэмээн Их Эзэн ийн айлдаж байна.

2 Мөн чамайг “хүлээж авдаг тэрээр намайг хүлээж авдаг; мөн миний Ариун Сүнсний ^билэрхийллээр миний үгийг тунхаглах хүч чамд байх болно.

3 Мөн бяцхан хүүхэд “адилаар чамайг хүлээн авдаг тэрээр миний ^бхаант улсыг хүлээж авдаг; мөн адислагдсан болой тэд, учир нь тэд ^бнигүүлслийг олж авах болно.

4 Мөн чамайг “няцаадаг хэн боловч миний Эцэг хийгээд түүний өргөөнөөс няцаагдах болно; мөн зам зуураа чи тэдний эсрэг гэрчлэл болгон нууц газруудад ^бхөлөө цэвэрлэх ёстой.

5 Мөн болгоогтун, мөн харагтун, номын ботид энэ нь миний талаар бичигдсэнчлэн миний эсрэг тэдний үйлдсэн бурханлиг бус бүх үйлүүдийг нотлохоор “шүүлтэд би удахгүй ^бирэх бөлгөө.

6 Мөн эдүгээ, үнэнээр би чамд хэлж байна, хүүхдүүд чинь хангагдаж мөн Сионы бишопт сайхан сэтгэлээр илгээгдэх хүртэл чи явах нь шаардлагатай бус байна.

7 Мөн хэдхэн жилийн дараа, хэрэв чи надаас хүсэх аваас, өөрсдийн өвийг эзэмшихээр сайн газар уруу чи тэрчлэн явж болох авай;

8 Өөрөөр, чи авагдах “хүртлээ миний сайн мэдээг тунхаглахаа үргэлжлүүлэх ёстой. Амен.

ХЭСЭГ 100

1833 оны аравдугаар сарын 12-нд Нью-Йоркийн Перрисбургт Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон хоёрт өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:416, 419–421). Хоёр ах гэр бүлээсээ хэдэн өдрийн турш хол байж, тэднийхээ талаар санаа нилээд зовжээ.

<p>99 1а су Хавчих, Хавчлага. 2а Мат. 10:40. б 1 Кор. 2:4–5. 3а Мат. 18:1–6. б су Бурханы хаант</p>	<p>улс буюу Тэнгэрийн хаант улс. в су Нигүүлсэнгүй, Нигүүлсэл. 4а Иохан 12:44–50. б С ба Г 75:19–22.</p>	<p>5а Иудей 1:14–15. су Есүс Христ—Шүүгч. б С ба Г 1:11–14. 8а Мат. 19:29.</p>
---	--	--

1–4, Иосеф, Сидней хоёр бодгалиудын авралын тулд сайн мэдээг номлох ёстой; 5–8, Тэд юу хэлэх ёстой нь яг тухайн цагт тэдэнд өгөгдөх болно; 9–12, Сидней төлөөлөн яригч байх ёстой мөн Иосеф илчлэгч мөн гэрчлэлд хүчтэй байх ёстой; 13–17, Их Эзэн цэвэр ариун хүмүүсийг бэлтгэх болно, мөн дуулгавартнууд аврагдах болно.

ҮНЭНЭЭР Их Эзэн ийн хэлж байна, миний найзууд “Сидней мөн ^бИосеф, та нарын гэр бүлүүд сайн байна; тэд миний мутарт буй, мөн би өөрт сайн санагдсаныг тэдэнд үйлдэх болно; учир нь надад бүх хүч буй.

2 Тиймийн тул, намайг дагагтун, мөн та нарт миний өгөх зөвлөгөөг дуулагтун.

3 Болгоогтун, мөн харагтун, энэ газарт мөн эргэн тойрны нутгуудад надад их хүмүүс буй; мөн дорнын энэ нутагдахь эргэн тойрны нутгуудад үр дүнтэй хаалга нээгдэх болно.

4 Тиймийн тул, Их Эзэн бибээр энэ газарт та нарыг очихыг зөвшөөрч байна; учир нь энэ нь бодгалиудын “авралын тулд надад шаардлагатай байна.

5 Тиймийн тул, үнэнээр би та нарт хэлж байна, энэ хүмүүст дуу хоолойгоо өргөг-

түн; зүрх сэтгэлд тань миний тавих бодлуудыг “яригтун, мөн та нар хүмүүсийн өмнө мадлагдах нь үгүй.

6 Учир нь тийм ээ, та нар юу хэлэх ёстой нь яг тухайн цагт та нарт “өгөгдөх болно.

7 Харин та нар ямар ч зүйлийг тунхаглах ёстой боллоо гэсэн та нар бүх зүйлд миний нэрээр зүрх сэтгэлийн чанд байдалд, “номхон дөлгөөн байдлын сүнсэнд та нар ^бтунхаглагтун хэмээх зарлигийг би та нарт өгч байна.

8 Мөн та нар үүнийг үйлдэхийн хэрээр, “Ариун Сүнс та нарын хэлэх юуг ч байлаа бүх зүйлд гэрч болон урагш юүлэгдэх болно хэмээх энэхүү амлалтыг би та нарт өгч байна.

9 Мөн миний үйлчлэгч Сидней чи энэ хүмүүст “төлөөлөн яригч байх ёстой нь надад шаардлагатай болой, тийм ээ, үнэнээр би чамайг энэ дуудлагад, бүр миний үйлчлэгч Иосефийн өмнөөс төлөөлөн яригч байхаар томилох болно.

10 Мөн “гэрчлэлд хүчирхэг байх хүчийг би түүнд өгөх болно.

11 Мөн чи түүний өмнөөс төлөөлөн яригч байж болохын тулд, бүх судруудыг тайлбарлахад “хүчирхэг байх хүчийг би чамд өгөх болно мөн дэлхий дээрх миний

100 1а су Сидней Ригдон.
б су Бага Иосеф Смит
4а су Аврал.
5а Хил 5:18;
С ба Г 68:3–4.

6а Мат. 10:19–20;
С ба Г 84:85.
7а су Номхон дөлгөөн, Номхон дөлгөөн байдал.
б С ба Г 84:61.

8а 2 Ниф. 33:1–4.
9а Ег. 4:14–16;
2 Ниф. 3:17–18;
С ба Г 124:103–104.
10а су Гэрчлэх.
11а Алма 17:2–3.

хаант улсын зүйлүүдэд хамаарах бүх зүйлийн тодорхой байдлыг чи мэдэж болохын тулд тэрээр чамд ⁶илчлэгч байх болно.

12 Тиймийн тул, аяллаа үргэлжлүүлж, мөн зүрх сэтгэл чинь баясаг; учрыг болгоогтун, мөн харагтун, бүр төгсгөлийг хүртэл би та нартай хамт байна.

13 Мөн эдүгээ “Сионы талаар нэг үгийг би чамд өгье. Багахан хугацаанд тэр гэсгээн цээрлүүлэгдсэн хэдий ч, Сион ⁶гэтэлгэгдэх болно.

14 Миний үйлчлэгчид, чиний ах Оорсон “Хайд мөн

Жон Гоулд нар миний муртарт буй; мөн тэд миний зарлигуудыг сахихын хэрээр тэд аврагдах болно.

15 Тиймийн тул, зүрх сэтгэл тань ая тухтай байг; учир нь цэх шулуун алхдаг тэдний сайн сайхны тулд, мөн сүмийн ариусгалд “бүх зүйл хамтдаа үйлчлэх болно.

16 Учир нь зөв шударга байдалд надад үйлчлэх “цэвэр ариун хүмүүсийг би өөртөө бэлтгэх болно;

17 Мөн Их Эзэний нэрийг “дуудаж, мөн түүний зарчмуудыг сахьдаг тэд бүгд аврагдах болно. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 101

1833 оны арванхоёрдугаар сарын 16-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:458–464). Энэ үед Миссурид цугларсан Гэгээнтнүүд агуу мөрдлөг хавчлагад өртсөн байв. Танхайрагчид тэднийг Жаксон гүнлэг дэх гэр орноос нь хөөв; мөн Гэгээнтнүүдийн зарим нь Ван Вурен гүнлэгт суурьшихыг оролдсон хэдий ч, мөрдлөг хавчлага тэднийг дагав. Гэгээнтнүүдийн үндсэн хэсэг тэр үед Миссурийн Клей гүнлэгт байлаа. Сүмийн хувь хүмүүсийг хөнөөхөөр заналхийлсэн тохиолдол олон байв. Хүмүүс гэрийнхээ тавилга, хувцас хунар, мал болон хувийн бусад эд хөрөнгөө алджээ; мөн тэдний их хэмжээний ургац устгагдсан байв.

1–8, Гэгээнтнүүд зөрчлийнхөө улмаас зэмлэгдэж мөн зовлон зүдгүүр амсав; 9–15, Их Эзэний зэвүүцэл үндэстнүүд дээр унах болно, харин түүний хүмүүс цугларч мөн тайтгаруулагдах болно; 16–21, Сион болон түү-

ний гадсууд бэхжүүлэгдэх болно; 22–31, Мянганы үе дэх амьдралын мөн чанар тайлбарлагдав; 32–42, Гэгээнтнүүд тэр үед адислагдаж мөн шагнагдах болно; 43–62, Язгууртны хийгээд чидун моднуудын тухай сургаалт

116 С ба Г 124:125.
13а су Сион.
б С ба Г 84:99;
105:9–10, 31, 37.

14а су Оорсон Хайд.
15а Ром. 8:28;
С ба Г 90:24; 105:40.
16а су Цэвэр ариун,

Цэвэр ариун байдал.
17а Иоел 2:32;
Алма 38:4–5.

зүйрлэл нь Сионы гай зовлон бэрхшээл хийгээд эцсийн гэтэлгэлийг бэлэгддэг; 63–75, Гэгээнтнүүд цугларахаа үргэлжлүүлэх ёстой; 76–80, Их Эзэн Нэгдсэн Улсын Үндсэн Хуулийг тогтоосон юм; 81–101, Эмэгтэй ба шударга биш шүүгчийн тухай сургаалт зүйрлэлийн дагуу Гэгээнтнүүд гомдлоо барагдуулахын тулд шаргуу гуйх ёстой.

ҮНЭНЭЭР би та нарт хэлж байна, зовж зүдрэн, мөн “хавчигдан мөрдөгдөж, мөн өвийнхөө нутгаас ^бхөөгдсөн ах дүүсийн чинь талаар буюу—

2 Их Эзэн, бибээр өөрсдийнх нь “зөрчлийн улмаас тэдэн дээр ирсэн ^бзовлон зүдгүүрээр тэд зовж зүдрэн буйг зөвшөөрсөн билээ;

3 Би тэднийг эзэмших учраас, өөрийн эрдэнэсийг сонгож авахаар намайг ирэх тэр өдөр тэд “минийх байх болно.

4 Тиймийн тул, цорын ганц хүүгээ тахилд өргөхийг зарлиглуулсан бүр “Абрахамын адилаар ^бгэгсгээн цээрлүүлэгдэж мөн соригдох ёстой нь шаардлагатай байна.

5 Учир нь гэгсгээн цээрлүү-

лэлтийг тэвчихгүй, харин намайг “үгүйсгэдэг тэд бүгд, ^бариусгагдаж чадах нь үгүй.

6 Болгоогтун, би та нарт хэлж байна, хэрүүл мөн “зөрчилдөөн, мөн ^батаархал бас маргаан, мөн ^бтачаангуй хийгээд шунахай хүслүүд тэдний дунд байв; тиймийн тул тэд эдгээр зүйлүүдээр өөрсдийн өвийг бохирложээ.

7 Тэд Бурхан Их Эзэнийхээ дуу хоолойг “сонсоход хөшүүн хойрго байлаа; тиймийн тул, Бурхан Их Эзэн нь тэдний залбирлуудыг сонсож, гай зовлонгийнх нь өдөрт тэдэнд хариулахдаа удаан байгаа болой.

8 Амар амгалангийнхаа өдөрт тэд миний зөвлөгөөг ялимгүй хүндэтгэдэг байв; харин “гай зовлонгийн өдөрт, гачигдалд намайг тэд ^бэрж хайдаг.

9 Үнэнээр би та нарт хэлж байна, тэдний нүглүүдийг үл харгалзан, миний дотор тэднийг “өрөвдөх сэтгэлээр дүүрдэг билээ. Би тэднийг ерөөсөө ^бзайлуулахгүй байх болно; мөн “хилэгнэлийн өдөрт бибээр нигүүлслийг санах болно.

10 Би эзвүүцлийнхээ “илдийг

101 1a су Хавчих,
Хавчлага.

б С ба Г 103:1–2, 11;
109:47.

2a Мозая 7:29–30;
С ба Г 103:4;
105:2–10.

б С ба Г 58:3–4.

3a Иса. 62:3;
Малах. 3:17;
С ба Г 60:4.

4a Эхл. 22:1–14;

Иаков 4:5.

су Абрахам.

б С ба Г 95:1–2; 136:31.
су Зэмлэх, Зэмлэл.

5a Мат. 10:32–33;
Ром. 1:16;
2 Ниф. 31:14.

б су Ариусгал.

6a су Уруу таталт.

б су Атаархал.
в су Тачаадах.

7a Иса. 59:2;

Мозая 11:22–25;
21:15;

Алма 5:38.

8a Хил. 12:3.

б Үйлс 17:27;

Алма 32:5–16.

9a су Өрөвч сэтгэл;
Нигүүлсэнгүй,
Нигүүлсэл.

б Иер. 30:11.

в С ба Г 98:21–22.

10a С ба Г 1:13–14.

өөрийн хүмүүсийн нэрийн өмнөөс унахаар болгоно хэмээх тогтоол нь та нарт миний өгсөн урьдын нэг зарлигаар урагш одсон бөгөөд бибээр андгайлсан билээ; мөн бүр миний хэлсэнчлэн, энэ нь улиран тохиох болно.

11 Миний зэвүүцэл бүх үндэстнүүд дээр мөдхөн хэмжээ хязгааргүйгээр юүлэгдэх болой; мөн тэдний алдсын аяга “дүүрэх үед би үүнийг хийх болно.

12 Мөн тэр өдөр “харуулын цамхаг дээр олдох тэд бүгд, эсвээс өөрөөр хэлбэл, миний бүх Израил аврагдах болно.

13 Мөн тараагдсан тэд “цуглуулагдах болно.

14 Мөн “гашуудаж байсан тэд бүгд тайтгаруулагдах болно.

15 Мөн миний нэрийн төлөө “амиа өгсөн тэд бүгд титэмлэгдэх болно.

16 Тиймийн тул, Сионы талаар зүрх сэтгэл чинь тайван байг; учир нь бүх махан бодь миний “мутарт байна; хөдөлгөөнгүй байж мөн би бол Бурхан гэдгийг “мэдэгтүн.

17 Хүүхдүүд нь тараагдсан хэдий ч, “Сион байрнаасаа хөдөлгөгдөх нь үгүй.

18 Үлдэх тэд, мөн зүрх сэтгэлдээ ариун болох тэд, эргэж ирэх болно, мөн тэд хийгээд тэдний хүүхдүүд үүрдийн баяслын “дуунуудтайгаар өөрсдийн “өвд мөн Сионы балгас болсон газруудыг “сэргээн босгохоор ирэх бөлгөө—

19 Мөн бошиглогчдын хэлсэн эдгээр бүх зүйл гүйцэлдэхийн тулд болой.

20 Мөн, болгоогтун, мөн миний тогтоосноос өөр ямар ч “газар тэнд байхгүй; миний гэгээнтнүүдийг цуглуулах ажлын төлөө миний тогтоосноос өөр ямар ч газар тэнд үгүй билээ—

21 Тэдний тулд дахиад зай олдохгүй байх тэрхүү өдрийг ирэх хүртэл буюу; мөн тэгээд тэдэнд миний тогтоож өгөх өөр газрууд надад бий, мөн Сионы хүчин чадал буюу хөшигнүүдийн тулд тэдгээр нь “гадаснууд хэмээн нэрлэгдэх болно.

22 Болгоогтун, миний нэрийг дууддаг, мөн миний үүрдийн сайн мэдээний дагуу намайг шүтэн биширдэг тэд бүгд хамтдаа “цуглаж, мөн ариун газрууд дээр “зогсох ёстой нь миний таалал билээ;

11a Хил. 13:14;

Ифер 2:9–11.

12a су Харах, Харуул.

13a Дэд хуул 30:3–6;

1 Ниф. 10:14.

су Израил—

Израилын цугларалт.

14a Мат. 5:4.

15a Мат. 10:39.

су Санаатайгаар

алах, Санаатай аллага.

16a Мосе 6:32.

б Ег. 14:13–14;

Дуул. 46:10.

17a су Сион.

18a Иса. 35:10;

С ба Г 45:71.

су Дуулах.

б С ба Г 103:11–14.

в Амос 9:13–15;

С ба Г 84:2–5; 103:11.

20a С ба Г 57:1–4.

21a С ба Г 82:13–14;

115:6, 17–18.

су Гадас.

22a су Израил—

Израилын цугларалт.

б Мат. 24:15;

С ба Г 45:32; 115:6.

23 Мөн миний асар дахь ариун сүмийг минь бүрсэн, дэлхийг нуудаг “хөшиг авагдахад ирэх илчлэлтийн төлөө бэлтгэгтүн, мөн бүх махан бодь намайг хамтдаа ^бхарах болно.

24 Мөн дэлхийн бүх гадаргуу дээр оршин амьдардаг “ялзрагч бүх зүйл, хүмүүн эсвээс тэжээмэл амьтад, эсвээс тэнгэрийн жигүүртнүүд, эсвээс далай тэнгисийн загас аль аль нь бүрмөсөн ^бустгагдах болно.

25 Мөн тэрчлэн элементүүд ч шатаам халуунд “хайлах болно; миний мэдлэг хийгээд ^бсүр жавхлан бүх дэлхий дээр оршиж болохын тулд бүх зүйл ^бшинэ болох болно.

26 Мөн тэр өдөр хүмүүний “дайсагнал, мөн амьтдын дайсагнал, тийм ээ, бүх махан бодийн дайсагнал миний нүүрний өмнө ^ббайхгүй болно.

27 Мөн тэр өдөр ямар ч хүн юуг ч асуулаа гэсэн, энэ нь түүнд өгөгдөх болно.

28 Мөн тэр өдөр аль ч хүмүүнийг уруу татах хүч “Сатанд байхгүй байх болно.

29 Мөн үхэл байхгүйн учир “уй гашуу байхгүй байх болно.

30 Тэр өдөр “нялх балчир тэр нь хөгшрөх хүртлээ наснаас халихгүй байх болно; мөн түүний амьдрал модны нас адил байх болно;

31 Мөн тэр наснаас халихдаа, дэлхийд хэлдгийн адил нойрсох нь үгүй, харин нүдээ анивчихад “өөрчлөгдөх болно, мөн дээш ^баваачигдаж мөн амралт нь гайхамшигтай байх болно.

32 Тийм ээ, үнэнээр би та нарт хэлж байна, Их Эзэн бибээр ирэх тэр “өдөр бүх зүйлийг ^билчлэх болно —

33 Улиран өнгөрсөн зүйлүүд мөн хүмүүний мэддэггүй байсан “нуугдмал зүйлүүд үүгээр энэ нь хийгдсэн дэлхийн зүйлүүдийг, мөн үүний зорилго хийгээд төгсгөлийг буюу.

34 Хамгийн их үнэт зүйлүүд, дээр байдаг зүйлүүд, мөн дор байдаг зүйлүүд, дэлхийн дотор, мөн дэлхий дээр байдаг, мөн тэнгэрт байдаг зүйлүүдийг буюу.

35 Мөн миний нэрний учир “мөрдлөг хавчлагыг тэсвэрлэдэг, мөн итгэлд тэвчдэг тэд бүгд, миний ^бтөлөө амиа зо-

23a су Хөшиг.

^б Иса. 40:5;

С ба Г 38:8; 93:1.

су Есус Христийн

Хоёр дахь Ирэлт.

24a С ба Г 29:24.

^б Зеф. 1:2–3;

Малах. 4:1;

С ба Г 88:94;

ИС—Т 1:37.

25a Амос 9:5;

2 Петр 3:10–14.

су Дэлхий—

Дэлхийн

цэвэршилт.

^б су Мянган жил.

^в Илч. 21:5.

26a Иса. 11:6–9.

су Дайсагнал.

^б су Амар амгалан.

28a Илч. 20:2–3;

1 Ниф. 22:26;

С ба Г 88:110.

29a Илч. 21:4.

30a Иса. 65:20–22;

С ба Г 63:51.

31a 1 Кор. 15:52;

С ба Г 43:32.

^б 1 Тес. 4:16–17.

32a С ба Г 29:11.

су Мянган жил.

^б С ба Г 121:26–28.

33a су Бурханы

нууцууд.

35a С ба Г 63:20.

су Хавчих,

Хавчлага.

^б С ба Г 98:13.

риулахаар дуудагдсан учраас тэд энэ бүх алдар суугаас хүртэх болно.

36 Иймийн тул, бүр “үхэлд ч бүү эмээ. Учир нь энэ дэлхийд та нарын баясал бүрэн биш болой, харин миний дотор та нарын баясал бүрэн болой.

37 Тиймийн тул, биеийн төлөө ч мөн биеийн амьдралын төлөө ч санаа бүү зов; харин “бодгалийн төлөө мөн бодгалийн амьдралын төлөө санаа тавь.

38 Мөн та нар өөрсдийн “тэвчээрээр бодгалиудаа олж авч болохын тулд, Их Эзэний нүүрийг ямагт б⁶эрэлхийл мөн та нар мөнх амьдралтай байх болно.

39 Хүмүүс миний “үүрдийн сайн мэдээнд дуудагдахад мөн үүрдийн гэрээгээр гэрээнд ороход тэд газрын давс ба хүмүүний амт хэмээн тооцогддог билээ;

40 Тэд хүмүүний амт байхаар дуудагдсан билээ; тиймийн тул, хэрэв газрын тэр давс амтаа алдах юм бол, болгоогтун, энэ цагаас эхлэн энэ нь юунд ч хэрэггүй болж зөвхөн хаягдаж, хүмүүний хөл дор дэвслэгдэх буйза.

41 Болгоогтун, Сионы хүүхдүүдийн, харин бүгдийнх нь биш, бүр олных нь хувьд

энэ нь мэргэн ухаан болой; тэд зөрчил гаргагчид болсон бөлгөө, тиймийн тул, тэд “гэсгээн цээрлүүлэгдэх ёстой нь шаардлагатай байна —

42 Өөрийгөө “өргөмжилдөг тэрээр доош тавигдах болно, мөн өөрийгөө б⁶доош тавьдаг тэрээр өргөмжлөгдөх болно.

43 Мөн эдүгээ, Сионы гэтэлгэлийн талаарх миний тааллыг та нар мэдэж болохын тулд, би та нарт сургаалт зүйрлэлийг үзүүлэх болно.

44 Нэг “язгууртан хүн, нэн сайн хэсэгхэн газартай байж; мөн тэрээр зарц нартаа хэлсэн нь: Та нар миний б⁶жимсний цэцэрлэгт бүр нэн сайн энэ хэсэг газар дээр очиж, мөн чидуны арванхоёр мод таригтун;

45 Мөн эргэн тойрны газрыг хэн нэг нь хянаж болохын тулд, миний чидуны моднуудыг гэмтээхээр дайсан ирж мөн жимсний цэцэрлэгийн минь жимсийг өөрсөд дээрээ авахад хугарахгүйн тулд, мөн цамхаг дээр харуул байхын тулд, тэдгээрийн эргэн тойронд “харуулуудыг тавьж, цамхаг барь.

46 Эдүгээ, язгууртны зарц нар явж, эзэн нь тэдэнд зарлигласны дагуу хийж, мөн чидуны моднуудыг тарьж,

36a су Биеийн үхэл.

б су Баяр баясгалан.

37a су Бие.

38a су Тэвчээр.

б Шаст. дэд 7:14;

С ба Г 93:1.

39a су Шинэ бөгөөд үүрдийн гэрээ.

б Мат. 5:13;

С ба Г 103:10.

41a су Зэмлэх, Зэмлэл.

42a Обад. 1:3–4;

Лук 14:11;

Хил. 4:12–13.

б Лук 18:14.

су Даруу, Даруу

байдал.

44a С ба Г 103:21–22.

б су Их Эзэний

талбай.

45a Езек. 33:2, 7;

3 Ниф. 16:18.

су Харax, Харуул.

мөн эргэн тойронд нь хашаа барьж, харуулууд тавиад, мөн цамхаг барьж эхэлжээ.

47 Мөн тэд үүний суурийг дөнгөж тавьж байх зуур тэд өөр хоорондоо: Миний эзэнд энэ цамхгийн хэрэг юу байдаг байна аа? хэмээн ярьж эхлэв.

48 Мөн өөр хоорондоо ярилцан, удаан хугацаагаар зөвлөлдөв; энэ бол амар амгалан цаг гэдгийг харсаар атал миний эзэнд энэ цамхгийн хэрэг юу байна аа?

49 Энэ мөнгийг арилжаачдад өгч болохгүй гэж үү? Учир нь эдгээр зүйлүүдийн хэрэгцээ алга.

50 Мөн тэд бие биентэйгээ зөрөлдөж байх зуур тэд их залхуу болж эзнийхээ зарлигуудыг анхаарахаа болив.

51 Мөн дайсан шөнөөр ирж, мөн хашааг “эвдэв; мөн язгууртны зарц нар босч мөн айж мөн зугтав; мөн дайсан тэдний ажлуудыг устгаж, мөн чидуны моднуудыг хугалжээ.

52 Эдүгээ болгоогтун, сайхь язгууртан, жимсний цэцэрлэгийн эзэн зарц нараа дуудаж, мөн тэдэнд хэлсэн нь, Яагаад? Энэхүү их азгүй явдлын шалтгаан юу вэ?

53 Та нарт миний зарлигласнаар үйлдэх ёсгүй байсан гэж үү, мөн — та нар жимсний цэцэрлэгийг тарьсны, мөн эргэн тойронд нь хашаа барьсны, мөн үүний хананууд дээр харуулууд тавьсны да-

раа дайсан та нар дээр ирэхгүйн тулд цамхгийг тэрчлэн барьж, цамхаг дээр харуулыг тавьж мөн миний жимсний цэцэрлэгийн тулд сэрэмжтэй байн мөн бөх унтахгүй байх ёстой байсан биш үү?

54 Мөн болгоогтун, мөн цамхаг дээрх харуул дайсныг хол байхад нь харах байсан юм; мөн тэгээд та нар бэлэн болж мөн дайсан үүний хашааг эвдэхээс хамгаалж, мөн жимсний минь цэцэрлэгийг устгагчийн гараас аварч чадах байсан бөлгөө.

55 Мөн жимсний цэцэрлэгийн эзэн зарц нарынхаа нэгэнд хэлсэн нь: Явж мөн зарц нарын минь үлдсэнийг, тэрчлэн миний гэрийн “бүх хүчин чадал болох миний зарц нарын доторх миний залуу эрчүүд болох, дунд насныхан болох миний дайчдыг аван, зөвхөн миний үлдэхээр томилсон тэднээс бусад миний гэрийн хүчин чадлыг хамтад нь цуглуул;

56 Мөн та нар миний жимсний цэцэрлэг уруу даруй очиж, мөн жимсний минь цэцэрлэгийг гэтэлгэгтүн; учир нь энэ нь минийх бөлгөө; би үүнийг мөнгөөр худалдаж авсан билээ.

57 Гиймийн тул, та нар миний газар уруу даруй очигтун; миний дайснуудын ханануудыг эвд; тэдний цамхгуудыг нураа, мөн тэдний харуулуудыг тараа.

58 Мөн тэд та нарын эсрэг

хамтдаа цуглахын хэрээр, би гэрийнхний үлдсэнтэй хамт хурдан очиж уг газрыг эзэмшиж болохын тулд дайс-нуудаас минь миний “өс хонзонууд ав.

59 Мөн зарц эзэндээ хэлсэн нь: Эдгээр зүйлүүд хэзээ болох вэ?

60 Мөн тэрээр зарцдаа хэлэв: Намайг хүсэх үед; та нар даруй оч, мөн та нарт миний зарлигласан юуг ч болов бүх зүйлийг хий;

61 Мөн энэ нь та нар дээрх миний лац хийгээд адислал—миний гэрийн дундах итгэлтэй мөн “мэргэн даамал, миний хаант улс дахь захирагч байх болно.

62 Мөн түүний зарц тэр даруй явж, мөн эзэн нь түүнд зарлигласан юуг ч болов бүх зүйлийг хийжээ; мөн олон өдрийн “дараа бүх зүйл гүйцэлдсэн байлаа.

63 Дахин, үнэнээр би та нарт хэлж байна, өөрсдийн авралын тулд зөв хийгээд зохих замаар удирдагдахыг хүсэхийн хэрээр бүх сүмийн талаар надад орших мэргэн ухааныг би та нарт үзүүлэх болно—

64 Миний гэгээнтнүүдийн хамтдаа цугларах ажил үргэлжилж болохын тулд, би тэднийг “ариун газруудад өөрийн нэрээр бэхжүүлэхийн

тулд буюу; учир нь “ургац хураалтын цаг айсуй, мөн миний үг “гүйцэлдэх ёстой нь шаардагдаж байна.

65 Тиймийн тул, хүн бүрийг ажлынх нь байгаагийн дагуу шагнахаар Эцэгийнхээ хаант улсад намайг ирэхэд улаан буудай нь саравчнуудад аюулгүйгээр нөөцлөгдөж, мөнх амьдралыг эзэмшихийн тулд, мөн “сэлэстиэл алдар суугаар титэмлэгдэхийн тулд улаан буудай ба “зэрлэг өвсний тухай сургаалт зүйрлэлийн дагуу би өөрийн хүмүүсийг хамтад нь цуглуулах ёстой;

66 Зэрлэг өвснүүд боодлуудад боогдох үед, тэдгээр нь унтаршгүй галд “шатаагдаж болохын тулд, уяанууд нь бөх болгогдох болно.

67 Тиймийн тул, тэд миний тогтоосон газруудад хамтдаа цуглахаа үргэлжлүүл хэмээх зарлигийг бүх сүмд би өгч байна.

68 Гэсэн хэдий ч, та нарт миний урьд нь өгсөн нэг зарлигт миний хэлсэнчлэн, та нарын цугларалт “яаруу тэвдүүд ч биш, зугталтаар ч биш байг; харин бүх зүйл та нарт урьдчилан бэлтгэгдэг.

69 Мөн бүх зүйл та нарын өмнө бэлтгэгдэхийн тулд, эдгээр зүйлүүдийн талаар

58a С ба Г 97:22–24; 105:15.

61a С ба Г 78:22.

б Мат. 25:20–23.

62a С ба Г 105:37.

64a С ба Г 87:8.

б С ба Г 33:3, 7.

су Ургац хураалт.

в С ба Г 1:38.

65a су Селестиел

алдар суу.

б Мат. 13:6–43;

С ба Г 86:1–7.

66a Нахум 1:5;

Мат. 3:12;

С ба Г 38:12;

63:33–34.

68a С ба Г 58:56.

миний өгсөн зарлигуудыг анхааралтай дага —

70 Энэ нь бүх газрыг мөнгөөр “худалдаж авахыг хэлдэг буюу заадаг, миний гэгээнтнүүдийн цугларалтын эхлэлийн тулд эргэн тойрны бүс нутагт Сионы нутаг байхаар миний тогтоосон газар мөнгөөр худалдан авагдаж болох бөлгөө;

71 Жаксон гүнлэгт мөн эргэн тойрны гүнлэгүүдэд худалдан авагдаж болох бүх газар буюу, мөн үлдсэнийг нь миний гарт үлдээгтүн.

72 Эдүгээ, үнэнээр би та нарт хэлж байна, бүх сүм өөрсдийн бүх мөнгөө хамтад нь цуглуулаг; эдгээр зүйлүүд тэдний цагт хийгдэг, гэвч “яаруу тэвдүү биш; мөн та нарт бүх зүйл урьдчилан бэлтгэгдэж байхыг анхаар.

73 Мөн шударга хүмүүс, бүр мэргэн хүмүүс томилогдог, мөн эдгээр газруудыг худалдаж авахаар тэднийг илгээгтүн.

74 Мөн дорнын мужууд дахь сүмүүд, тэдгээр нь байгуулагдсан үедээ, хэрэв тэд энэ зөвлөгөөг анхаарах аваас, газруудыг худалдан авч тэдгээр дээр хамтдаа цуглаж болно, мөн энэ замаар тэд Сионыг төлөвшүүлж болох бөлгөө.

75 Бүр эдүгээ аль хэдийн Сионыг гэтэлгэх, мөн дахин хаягдахгүйн тулд түүний

балгас болсон газруудыг сэргээн босгох, миний нэрээр өөрсдийгөө дууддаг, миний дуу хоолойг анхаарахыг “хүсдэг сүмүүдэд хангалттай нөөц, тийм ээ, бүр элбэг буй.

76 Мөн дахин би та нарт хэлж байна, дайснуудаараа тараагдсан тэд гомдлоо тайлахын тулд, мөн гэтэлгэлийн тулд захирагчдаар тавигдсан мөн та нарын дээр эрх мэдэлд буй тэдний гараас тэд шаргуу гуйхаа үргэлжлүүлэх ёстой нь миний таалал юм —

77 Шударга хийгээд ариун зарчмуудын дагуу бүх махан бодийн “эрх хийгээд хамгааллын тулд үндэслэн байгуулагдахыг нь, мөн баримтлагдах ёстойг нь миний хүлээн зөвшөөрсөн хүмүүсийн хуулиуд болон “үндсэн хуулийн дагуу буюу;

78 Миний өгсөн ёс суртахууны “сонгох эрхийн дагуу хүн болгон ирээдүйд хамаарах сургаал хийгээд зарчимд үйлдэж болохын тулд, “шүүлтийн өдөрт хүн болгон нүглүүдийнхээ төлөө “хариуцаж болохын тулд буюу.

79 Тиймийн тул, аливаа хүмүүн бие биендээ боолчлолд байх ёстой гэдэг нь зөв биш юм.

80 Мөн энэ зорилгын учир би чухамхүү энэ зорилгын тулд өөрийн бэлтгэсэн мэргэн хүмүүсийн гараар уг

70a С ба Г 63:27–29.

72a Иса. 52:10–12.

75a Алма 5:37–39.

77a су Эрх чөлөө.

б су Засгийн газар.

78a су Сонгох эрх.

б су Эцсийн шүүлт.

в су Хариуцах,

Хариуцлага,
Хариуцлагатай.

нутгийн “Үндсэн хуулийг тогтоож мөн цус ^бурсгалтаар уг нутгийг гэтэлгэсэн билээ.

81 Эдүгээ, Сионы хүүхдүүдийг би юутай адилтгах ёстой вэ? Би тэднийг эмэгтэй болон шударга бус шүүгчийн тухай “сургаалт зүйрлэлтэй адилтгах болно, учир нь хүмүүс ямагт ^бзалбирч мөн доройтохгүй байж ийн хэлэх учиртай —

82 Бурханаас эмээдэггүй, хүмүүнийг ч тоодоггүй нэг шүүгч нэг хотод байжээ.

83 Мөн тэр хотод нэг бэлэвсэн эмэгтэй байдаг байж, тэрээр түүн дээр ирж: Дайснаас минь миний өс хонзонг авч өгөөч хэмээн хэлжээ.

84 Мөн тэрээр хэсэг хугацаанд зөвшөөрсөнгүй, дараа нь тэрээр дотроо хэлсэн нь: Хэдийгээр би Бурханаас ч эмээдэггүй, хүмүүнийг ч тоодоггүй гэсэн, энэ бэлэвсэн эмэгтэй надад төвөг удаж буй учир тэрээр байнгын ирэлтээрээ намайг залхаахгүйн тулд өс хонзонг нь би авах болно.

85 Ийнхүү би Сионы хүүхдүүдийг адилтгах болно.

86 Тэд шүүгчийн хөл дор шаргуу гуйг!

87 Мөн хэрэв тэрээр тэднийг үл анхаарах аваас тэд захирагчийн хөлд шаргуу гуйг.

88 Мөн хэрэв захирагч

тэднийг үл анхаарах аваас, тэд ерөнхийлөгчийн хөлд шаргуу гуйг.

89 Мөн хэрэв ерөнхийлөгч та нарыг эс анхаарах аваас, тэгвэл Их Эзэн “нуугдсан газраасаа босч мөн урагш гарч ирэх болно, мөн уг үндэстэн түүний хорсолд зовох болой.

90 Мөн түүний үлэмж дургүйцэлд, мөн догшин ууранд, түүний цагт ёс бус, итгэлгүй хийгээд “шударга бус ^бдаамлууд тусгаарлагдах болно, мөн тэднийг хувьтай нь хамт хоёр нүүртнүүд хийгээд итгэл бишрэлгүйчүүдийн дунд томилох болно.

91 Бүр “уйлах, мөн гаслах, мөн шүдээ хавирах нь байдаг гадаад харанхуйд буюу.

92 Тиймийн тул, би тэдэнд “нигүүлсэнгүй байж болохын тулд, эдгээр зүйлүүд тэдэн дээр ирэхгүй байж болохын тулд, тэдний чих та нарын гуйлтуудад нээгдэхийн тулд залбирагтун та нар.

93 Бүх хүмүүн “шалтаггүй үлдэж болохын тулд та нарт миний хэлсэн нь шаардлагатай болой;

94 Мэргэн хүмүүс хийгээд захирагчид өөрсдийнхөө хэзээ ч “хайхардаггүй байсан зүйлээ сонсож мөн мэдэхийн тулд буюу;

95 Бибээр өөрийн үйлийг,

80a 2 Ниф. 1:7–9;
С ба Г 98:5–6.
су Үндсэн хууль.
б 1 Ниф. 13:13–19.
81a Лук 18:1–8.
б су Залбирал.
89a Иса. 45:15;

С ба Г 121:1, 4; 123:6.
90a Илч. 21:8.
су Итгэлгүй байдал.
б су Даамал, Ажил үүрэг.
91a Мат. 25:30;

С ба Г 19:5;
29:15–17; 124:8.
92a су Нигүүлсэнгүй, Нигүүлсэл.
93a Ром 1:18–21.
94a Иса. 52:15;
3 Ниф. 20:45; 21:8.

өөрийн “хачирхалтай үйлийг улируулан тохиолгож мөн өөрийн ажлыг, өөрийн хачирхалтай ажлыг гүйцэтгэж болохын тулд, хүмүүн зөв шударгачууд хийгээд ёс бусчуудыг хооронд нь “ялган таньж болохын тулд болой хэмээн та нарын Бурхан хэлдэг.

96 Мөн дахин, би та нарт хэлж байна, өөрийн хүмүүст миний тогтоож өгсөн “агуулахыг минь миний үйлчлэгч Сидней Гилберт дайснуудын маань гарт зарах нь миний зарлиг хийгээд миний таалалд харшилж байна.

97 Миний өгсөн зүйлс дайснуудаар минь, өөрсдийгөө миний нэрээр “нэрлэдэг тэдний зөвшилцлөөр бүү бохирлогдог.

98 Учир нь энэ нь миний эсрэг мөн миний хүмүүсийн эсрэг нэн зовлонтой хийгээд

гашуудмаар нүгэл бөгөөд миний тогтоосон, мөн үндэстнүүд дээр удалгүй тохиох ёстой тэр зүйлүүдийн улмаас буюу.

99 Тиймийн тул, хэдийгээр тэд үүн дээр амьдрахаар зөвшөөрөгдөх ёсгүй ч миний хүмүүс өөрсдөд нь миний өгсөн зүйлийг шаардах эрхтэй байх ёстой нь миний таалал бөлгөө.

100 Гэсэн хэдий ч, тэд үүн дээр амьдрах ёсгүй хэмээн би хэлдэггүй; учир нь тэд миний хаант улсад тохирох үр жимс хийгээд ажлуудыг урагш авчрахын хэрээр тэд үүн дээр амьдрах болно.

101 Тэд барих болно, мөн өөр хэн нэг нь үүнийг “өвлөхгүй байх болно; тэд жимсний цэцэрлэгийг тарих болно, мөн тэд үүний жимсийг хүртэх болно. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 102

1834 оны хоёрдугаар сарын 17-нд Огайогийн Көртландад болсон Сүмийн анхны дээд зөвлөлийн зохион байгуулалтын тэмдэглэл оршвой (History of the Church, 2:28–31). Жинхэнэ эх тэмдэглэлийг Ахлагч Каудери, Оорсон Хайд нар хийжээ. Хоёр өдрийн дараа тэмдэглэлийг Бошиглогч засч, дээд зөвлөлд уншиж өгч, мөн дээд зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн ажээ. Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөлийг бий болгохтой холбогдсон 30-аас 32-р шүлгүүдийг Бошиглогч Иосеф Смит 1835 онд тэрээр энэ хэсгийг Сургаал ба Гэрээний нийтлэлд зориулан бэлтгэж байхдаа нэмж оруулжээ.

1–8, Сүмд үүсэн бий болдог чухал бэрхшээлүүдийг шийдвэрлэхийн

тулд дээд зөвлөл томилогдов; 9–18, Хэрэг явдлуудыг сонсох

95а Иса. 28:21;
С ба Г 95:4.
б Малах. 3:18.
су Ялган таних

бэлэг.
96а су Агуулах.
97а С ба Г 103:4;
112:25–26; 125:2.

101а Иса. 65:21–22.
су Мянган жил.

журмууд өгөгдөв; 19–23, Зөвлөлийн ерөнхийлөгч шийдвэр гаргана; 24–34, Давж заалдах журам толилуулагдав.

ЭНЭ өдөр ерөнхий зөвлөлийн хорин дөрвөн дээд санваартан илчлэлтээр Бага Иосеф Смитийн гэрт цуглаж, арванхоёр дээд санваартан, мөн хэрэг шаардахын дагуу нэг буюу гурван ерөнхийлөгчөөс бүрдэх Христийн сүмийн “дээд зөвлөлийг зохион байгуулахаар зорив.

2 Дээд Зөвлөл нь, Сүмд үүсэн бий болж болох сүмээр буюу “бишопын зөвлөлөөр шийдвэрлэгдэж үл болох, талуудын сэтгэл ханамжтай байдалд чухал учир холбогдолтой бэрхшээлүүдийг шийдвэрлэх зорилгын тулд илчлэлтээр томилогдсон байлаа.

3 Бага Иосеф Смит, Сидней Ригдон, мөн Г.Виллямс нар зөвлөлийн дуу хоолойгоор ерөнхийлөгчдөөр хүлээн зөвшөөрөгдөв; мөн Ахмад Иосеф Смит, Жон Смит, Жозеф Көү, Жон Жонсон, Мартин Харрис, Жон С.Картер, Жаред Картер, Оливер Каудери, Самуел Х.Смит, Оорсон Хайд, Силвестер Смит мөн Лук Жонсон нарын дээд санваартнууд зөвлөлийн санал нэгтэй дуу хоолойгоор сүмийн байнгын зөвлөл болж сонгогдов.

4 Дээр нэрлэгдсэн зөвлөхүүдээс дараа нь тэд томи-

лолтуудыг хүлээн авч байгаа эсэхийг нь, мөн тэд тэрхүү албан тушаалд тэнгэрийн хуулийн дагуу ажиллахыг нь асуухад тэд бүгдээрээ өөрсдийн томилолтуудыг хүлээн авсныг, мөн өөрсдийн албан тушаалуудыг өөрсөд дээр нь соёрхсон Бурханы ач ивээлийн дагуу гүйцэлдүүлэх болно хэмээн хариулжээ.

5 Мөн сүмийн нэрээр хийгээд сүмийн төлөө дээр нэрлэгдсэн зөвлөхүүдийг томилоход санал өгсөн зөвлөлийг бүрдүүлэгч тоо нь дараах байдлаар дөчин гурав байсан нь: Есөн дээд дээд санваартан, арвандолоон ахлагч, дөрвөн санваартан мөн арвангурван гишүүн байв;

6 Санал өгсөн нь: Дээд зөвлөл нь дээр нэрлэгдсэн долоон зөвлөхгүйгээр эсвээс албан ёсоор томилогдсон тэдний залгамжлагчид байхгүйгээр үйлдэх хүчтэй байж үл чадна.

7 Эдгээр долоо нь зохистой хийгээд байхгүй байгаа зөвлөхүүдийн оронд ажиллах чадвартай хэмээн өөрсдийн үзсэн бусад дээд санваартнуудыг томилох хүчтэй байх ёстой.

8 Санал өгсөн нь: Нас баралтаар, зөрчлийн улмаас сүмийн энэхүү удирдлагын үүргүүдээс дээр нэрлэгдсэн зөвлөхүүдийн аль нэг нь албан тушаалаас сулрах аливаа орон тоо нь ерөнхийлөгч буюу ерөнхийлөгчдийн нэр

дэвшүүлэлтээр бөглөгдсөн, мөн уг зорилгын тулд хуралдсан дээд санваартнуудын ерөнхий зөвлөлийн дуу хоолойгоор сүмийн нэрээр үйлдэхээр зөвшөөрөгдөх ёстой.

9 Сүмийн ерөнхийлөгч, тэрчлэн уг зөвлөлийн ерөнхийлөгч тэр нь “илчлэлтээр томилогдож, мөн сүмийн дуу хоолойгоор өөрийн үйлчлэлд ^бхүлээн зөвшөөрөгдөнө.

10 Мөн тэрхүү албан тушаалын өндөр нэр хүндийн дагуу тэрээр сүмийн зөвлөлийг тэргүүлэх ёстой; мөн түүний өөрийнх нь адил маягаар томилогдсон хоёр өөр ерөнхийлөгчөөр туслуулдаг байх нь түүний онцгой боломж билээ.

11 Мөн түүнд туслахаар томилогдсон тэдний нэг нь буюу хоёул байхгүй тохиолдолд тэрээр туслагчгүйгээр зөвлөлийг тэргүүлэх хүчтэй байна; мөн тэрээр өөрөө байхгүй тохиолдолд, бусад ерөнхийлөгчид хоёул эсвээс аль нэг нь түүний оронд тэргүүлэх хүчтэй байна.

12 Христийн сүмийн дээд зөвлөл хэдийд ч албан ёсоор зохион байгуулагдахад, өмнөх загварын дагуу тоогоор шодож мөн нэгээс эхлэн дэс дарааллаар арванхоёр хүртэл хэн эхэнд нь ярих ёстойг үүгээр тогтоох нь арванхоёр зөвлөхийн үүрэг байх ёстой.

13 Хэдийд ч аливаа хэрэг дээр үйлдэхээр энэхүү зөвлөл

хуралдлаа гэсэн, арванхоёр зөвлөх энэ нь бэрхшээлтэй юү, үгүй юү гэдгийг авч үзэх ёстой; хэрэв энэ нь үгүй аваас, зөвлөхүүдээс зөвхөн хоёр нь дээр бичигдсэн хэлбэрийн дагуу үүн дээр ярих ёстой.

14 Харин хэрэв энэ нь бэрхшээлтэй гэж бодогдох аваас, дөрөв нь томилогдох болно; мөн хэрэв энэ нь илүү бэрхшээлтэй аваас, зургаа нь буюу; харин ямар ч тохиолдолд зургаагаас илүү нь ярихаар томилогдохгүй байх болно.

15 Гомдол хийгээд шударга бус явдлаас сэрэмжлэхийн тулд буруутнууд бүх хэрэгт зөвлөлийн хагасын эрхтэй байна.

16 Мөн зөвлөлийн өмнө ярихаар томилогдсон зөвлөхүүд нотолгоог шалгасны дараа хэргийг зөвлөлийн өмнө үнэн зөвөөр нь танилцуулах ёстой; мөн хүн болгон тэгш эрх хийгээд “шударга ёсны дагуу ярих ёстой.

17 Бүр 2, 4, 6, 8, 10, мөн 12-ын тоог сугалдаг зөвлөхүүд нь гомдол хийгээд буруутнуудын нэрийн өмнөөс зогсдог, мөн гомдол хийгээд шударга бус явдлаас сэрэмжлүүлдэг хувь хүмүүс байна.

18 Бүх хэрэгт буруутгагч болон буруутнууд нь нотолгоонуудыг сонсож, мөн тухайн хэргээр ярихаар томилогдсон зөвлөхүүд өөрсдийн санал дүгнэлтүүдийг дуусгас-

ны дараа өөрсдийнхөө төлөө үг хэлэх онцгой боломжтой байх болно.

19 Нотолгоонууд сонсогдож, буруутгагч хийгээд буруутнуудад зөвлөхүүд ярьсны дараа уг хэргийн талаар тэрээр ямар ойлголттой болсныхоо дагуу шийдвэр гаргаж, мөн арванхоёр зөвлөх өөрсдийн санал өгөлтөөр уг зүйлийг эвшөөрүүлэх хүсэлт тавина.

20 Харин яриагүй үлдсэн зөвлөхүүд, эсвэл тэднээс хэн нэгэн нь нотолгоонуудыг мөн мэдүүлгүүдийг шударгаар сонссоны дараа ерөнхийлөгчийн шийдвэрийн алдааг илрүүлж, тэд үүнийг мэдэгдэж болно, мөн хэргийг дахин сонсох ёстой.

21 Мөн хэрэв анхааралтайгаар дахин сонссоны дараа, уг хэрэгт ямар нэг зүйлс нэмэгдсэн бол, шийдвэр нь энэ дагуу өөрчлөгдөх ёстой.

22 Гэвч хэрэгт нэмэлт ороогүй бол зөвлөлийн олонх нь анхны шийдвэрийг тодорхойлох хүчтэй байж, энэ нь хэвээр үлдэх ёстой.

23 “Сургаал буюу зарчмын талаар бэрхшээл гарсан үед, хэрэв хэргийг зөвлөлийн санаа бодолд тодорхой болгох бичгээр хийсэн хангалттай мэдээлэл байхгүй бол ерөнхийлөгч ^билчлэлтээр асууж мөн Их Эзэний бодлыг олж авч болно.

24 Дээд санваартнууд, хол байхдаа талууд буюу тэдгээрийн аль нэг нь хүсэх үед

өмнөх байдлаар зөвлөлийг дуудаж мөн зохион байгуулах, бэрхшээлүүдийг шийдвэрлэх хүчтэй байна.

25 Мөн энд өгүүлсэн дээд санваартнуудын зөвлөл тухайн үед ийм зөвлөлийг тэргүүлэхийн тулд өөрсдийнхөө дотроос нэгийг нь томилох хүчтэй байх ёстой.

26 Өөрсдийн шийдвэрлэсэн хэргүүдийн нэг хувийг, шийдвэрийг нь дагалдах гэрчлэлийн бүрэн нотолгооны хамт тэр даруй Сүмийн Тэргүүн Зөвлөлийн суудал дахь дээд зөвлөлд шилжүүлэх нь энд өгүүлсэн зөвлөлийн үүрэг байх болно.

27 Талууд буюу тэдгээрийн аль нэг нь энд өгүүлсэн зөвлөлийн шийдвэрт сэтгэл ханамжгүй байгаа бол, тэд Сүмийн Тэргүүн Зөвлөлийн суудлын дээд зөвлөлд даван заалдаж болно, мөн бичгээр үйлдсэн өмнөх загварын дагуу, ийм шийдвэр гараагүй ч гэсэн, уг асуудал хөтлөгдөж дахин сонсогдож болно.

28 Хол байгаа дээд санваартнуудын энэхүү зөвлөлийг сүмийн хэрэг явдлуудын хамгийн “бэрхшээлтэй хэргүүдээр зарлан хуралдуулах ёстой; мөн нийтлэг биш буюу ердийн биш хэрэг нь ийм зөвлөлийг зарлан хуралдуулахад хангалттай болой.

29 Хол байгаа аялагч буюу дээд санваартнууд ийм зөвлөлийг зарлан хуралдуулах

шаардлагатай юу үгүй юу гэдгийг хэлэх хүчтэй байна.

30 Дээд зөвлөл буюу хол байгаа “аялагч дээд санваартнууд, мөн арванхоёр⁶ төлөөлөгчөөс бүрдсэн аялагч дээд зөвлөл, мөн тэдгээрийн шийдвэрүүдийн хооронд ялгаа буй.

31 Өмнөхийн шийдвэрээс даван заалдах нь байж болно; харин сүүлчийнхийн шийдвэрээс байж болохгүй.

32 Зөрчлийн тохиолдолд сүүлчийнхийг гагцхүү сүмийн ерөнхий эрх мэдэлтнүүд асууж болно.

33 Шийдвэрлэсэн нь: Сүмийн Тэргүүн Зөвлөлийн суудал дахь ерөнхийлөгч буюу ерөнхийлөгчид даван заалдаж болох ийм аливаа хэргийг даван заалт болон мөн дагалдагч нотолгоонууд

дыг шалгасны дараа дахин сонсох нь шударга хэмээн үзэхийг тодорхойлох хүчтэй байх ёстой.

34 Тэгээд хэн эхэлж ярих ёстойг шодох буюу сонгох хуудсаар Арванхоёр зөвлөх тогтоож, мөн дараах нь үр дүн нь болов, тухайлбал: 1, Оливер Каудери; 2, Жозеф Көү; 3, Самуел Х.Смит; 4, Лук Жонсон; 5, Жон С.Картер; 6, Силвестер Смит; 7, Жон Жонсон; 8, Оорсон Хайд; 9, Жаред Картер; 10, Ахмад Иосеф Смит; 11, Жон Смит; 12, Мартин Харрис. Залбирлын дараа чуулган өндөрлөв.

ОЛИВЕР КАУДЕРИ

ООРСОН ХАЙД

Бичиг хэргийн
ажилтнууд

ХЭСЭГ 103

1834 оны хоёрдугаар сарын 24-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 2:36–39). Гэгээнтнүүдийг хөнгөвчлөх хийгээд Жаксон гүнлэг дэх тэдний газруудыг сэргээх асуудлаар Бошиглогчтой зөвлөхөөр Парлей П.Пратт, Лайман Вайт хоёр Миссуригээс Огайогийн Көртландад ирсний дараа энэхүү илчлэлт хүлээн авагджээ.

1–4, Яагаад Их Эзэн Жаксон гүнлэг дэх Гэгээнтнүүд мөрдөн хавчигдахыг зөвшөөрөв; 5–10, Хэрэв Гэгээнтнүүд зарлигуудыг сахих аваас тэд дийлэх болно; 11–20, Сионы гэтэлгэл сүр хүчээр ирэх болно, мөн Их Эзэн өөрийн хүмүүсийн өмнө явах болно; 21–28, Гэгээнтнүүд Сионд цуглах ёстой, мөн амиа

зориулдаг тэд үүнийг дахин олж авах болно; 29–40, Нилээд олон ах нар Сионы Хуаранг зохион байгуулах, мөн Сион уруу явахаар дуудагдав; хэрэв тэд итгэлтэй байх аваас ялалт тэдэнд амлагдав.

Үнэнээр би та нарт хэлж байна, найз нар минь,

болгоогтун, Сионы нутагт тараагдсан ах нарынхаа аврал хийгээд “гэтэлгэлийн талаарх үүргүүдээ биелүүлээгүй тухайд хэрхэн ⁶үйлдэхийг та нар мэдэж болохын тулд би нэг илчлэлт болон зарлигийг та нарт өгөх болно;

2 Миний өөрийн цагт хилэгнэлээ тэдний дээр бибээр хэмжээлшгүй ихээр цугтах, миний дайснуудын гараар “туугдан мөн цохигдон байгааг нь буюу.

3 Учир нь тэд алдсуудынхаа хэмжээг “дүүргэж болохын тулд, тэдний аяга дүүрсэн байхын тулд би тэднийг ийн өдий хүртэл зөвшөөрсөн билээ.

4 Мөн миний нэрээр өөрсдийгөө дууддаг тэд бүгд багаахан учир шалтгааны улмаас зовлонтой хийгээд гашуудалтай “гэсгээн цээрлүүлэлтээр гэсгээн цээрлэгдэж болох бөлгөө; учир нь тэд өөрсдөд нь миний өгсөн заавар хийгээд зарлигуудыг нийтээрээ ⁶анхаараагүй билээ.

5 Харин би та нарт үнэнээр хэлж байна, яг энэ цагаас эхлэн тэд Их Эзэн, тэдний Бурхан, миний тэдэнд өгөх “зөвлөгөөг анхаарахын хэрээр миний хүмүүс олж авах болно хэмээх тогтоолыг би тогтоосон билээ.

6 Болгоогтун яг энэ цагаас эхлэн тэд миний дайснуудын эсрэг дийлж эхлэх болно, учир нь би үүнийг тогтоосон билээ.

7 Мөн Их Эзэн тэдний Бурхан миний тэдэнд хэлэх бүх үгсийг “анхаарснаар дэлхийн ⁶хаант улсууд миний хөл дор захирагдах хүртэл мөн дэлхий үүрд болон үргэлжид “эээмшихээр ‘гэгээнтнүүдэд ⁶өгөгдөх хүртэл тэд дийлэх нь хэзээ ч зогсохгүй байх болно.

8 Гэвч тэд миний зарлигуудыг “сахихгүй мөн миний бүх үгсийг анхаарахгүй байхын хэрээр, дэлхийн хаант улсууд тэдний эсрэг дийлсээр байх болно.

9 Учир нь тэд дэлхийн “гэрэл, мөн хүмүүний аврагчид байхаар болгогдсон байлаа;

10 Мөн тэд хүмүүний аврагчид байхгүй байхын хэрээр, тэд амтаа алдсан “давс мэт болох бөлгөө мөн тэр цагаас хойш зайлуулагдаж мөн хүмүүний улан дор гишгэгдэхээс өөр юунд ч хэрэггүй болдог.

11 Харин үнэнээр би та нарт хэлж байна, та нарын тараагдсан ах дүүс тань өвийнхөө “газруудад эргэж ирэх болно, мөн Сионы балгас болсон газруудыг сэргээн

103 1a С ба Г 101:43–62.

б С ба Г 43:8.

2a С ба Г 101:1; 109:47.

3a Алма 14:10–11;
60:13.

4a С ба Г 95:1.

су Зэмлэх, Зэмлэл.

б С ба Г 101:2; 105:2–6.

5a су Зөвлөгөө.

7a Дан. 2:44.

б С ба Г 35:24.

су Дуулгавартай байх, Дуулгавартай дагах.

в С ба Г 38:20.

г су Гэгээнтэн.

д Дан. 7:27.

8a Мозая 1:13;

С ба Г 82:10.

9a 1 Ниф. 21:6.

10a Мат. 5:13–16;

С ба Г 101:39–40.

11a С ба Г 101:18.

босгох болно хэмээн би тогтоож байна.

12 Учир нь, өмнөх зарлигтаа би та нарт хэлсэнчлэн, их “гай зовлонгийн дараа адислал ирдэг.

13 Болгоогтун, та нарын гэтэлгэл, мөн ах дүүсийн чинь гэтэлгэл, бүр Сионы газар нутагт тэдний сэргээлт төлөвшүүлэгдэж дахин доош хаягдахгүй байх нь та нарт миний амласан тэрхүү адислал бөлгөө.

14 Гэсэн хэдий ч, хэрэв тэд өвүүдээ бохирлох аваас тэд доош хаягдах болно; учир нь хэрэв тэд өвүүдээ бохирлох аваас би тэдний амийг хэлтрүүлэх нь үгүй.

15 Болгоогтун, би та нарт хэлж байна, Сионы гэтэлгэл хүчээр ирэх ёстой нь шаардлагатай бөлгөө.

16 Тиймийн тул, Израилын хүүхдүүдийг “Моце удирдсан лугаа адил тэднийг удирдах нэг хүнийг би өөрийн хүмүүсийн дунд бэлтгэх болно.

17 Учир нь та нар Израилын хүүхдүүд, мөн Абрахамын “үр удам билээ, мөн хүчээр, мөн сунгасан гараар та нар боолчлолоос удирдан гаргагдах ёстой нь шаардлагатай болой.

18 Мөн та нарын эцгүүд урьд нь удирдагдсан шиг, бүр Сионы гэтэлгэл тийм байх болой.

19 Тиймийн тул, зүрх сэтгэл чинь бүү унаг, учир нь би та нарын эцгүүдэд хэлсэн шигээ, би та нарт хэлэх нь үгүй: Миний “бие оршихуй биш, харин миний ^бтэнгэр элч та нарын өмнө явах болно.

20 Харин би та нарт хэлнэ: Та нар тэрхүү сайхан газар нутгийг “эзэмших тэр цагт миний ^бтэнгэр элчүүд, мөн тэрчлэн миний оршихуй та нарын өмнө явах болно.

21 Үнэнээр, үнэнээр би та нарт хэлж байна, миний үйлчлэгч Бага Иосеф Смит бол та нарт миний өгсөн сургаалт зүйрлэлийн “жимсний цэцэрлэгийн Эзэн түүнтэй ярьсан тэр зарцтай миний адилтгасан тэр ^бхүн юм.

22 Тиймийн тул, миний үйлчлэгч Бага Иосеф Смит, миний өргөөний “хүчин чадал, миний залуу эрчүүд болон дунд насныханд — надад ариулан адислагдсан мөнгөөр миний худалдаж авсан Сионы газар нутагт өөрсдийгөө хамтад нь цуглуулагтун хэмээн хэлэг.

23 Бүх сүмүүд ухаалаг эрчүүдийг мөнгөтэй нь хамт илгээг, мөн бүр тэдэнд миний зарлигласанчлан газрууд “худалдаж аваг.

24 Сионы нутаг байхаар миний ариулан адисалсан

12a Илч. 7:13–14;
С ба Г 58:4; 112:13.

16a Ег. 3:2–10;
С ба Г 107:91–92.
су Моце.

17a су Абрахам—
Абрахамын үр

удам; Абрахамын
гэрээ.

19a С ба Г 84:18–24.
б су Тэнгэр элчүүд.

20a С ба Г 100:13.
б Ег. 14:19–20.

21a су Их Эзэний

талбай.

б С ба Г 101:55–58.

22a С ба Г 35:13–14;
105:16, 29–30.

23a С ба Г 42:35–36;
57:5–7; 58:49–51;
101:68–74.

сайхан “газар нутгаас минь, бүр тэдний эсрэг эдгээр гэрчлэлүүдийг та нар миний өмнө авчирсны дараа өөрсдийн чинь нутгаас та нарыг хөөхөөр миний дайснууд та нарын эсрэг ирэхийн хэрээр, та нар тэднийг зүхэх ёстой;

25 Мөн та нар хэнийг ч зүхлээ гэсэн, би зүхэх болно, мөн та нар дайснуудаас минь миний өс хонзонг авах ёстой.

26 Мөн дайснуудаас минь миний “өс хонзонг авахад, бүр намайг үзэн яддаг тэдний гурав дахь болон дөрөв дэх үеийнхэн дээр миний оршихуй та нартай хамт байх болно.

27 Хүмүүн миний төлөө амиа “зориулахаас бүү айг; учир нь миний төлөө амиа зориулдаг хэн ч гэсэн үүнийгээ дахин олж авах болно.

28 Мөн миний төлөө амиа зориулахыг хүсдэггүй хэн ч гэсэн миний шавь биш болой.

29 Миний шавь “Сидней Ригдон, Сионы сэргээлт ба гэтэлгэлийн талаар тэдэнд миний өгсөн зарлигуудыг сахихад сүмүүдийг бэлтгэн, дорнын мужууд дахь цугларалтууд дээр дуу хоолойгоо өргөх ёстой нь миний таалал бөлгөө.

30 Миний үйлчлэгч Парлей П.“Пратт мөн миний үйлчлэгч Лаймен Вайт нар Сионы

нутаг өөд явах бүлэг эрсийг олох хүртлээ, миний өргөөний ⁶хүчин чадлаас таван зуун тооныхыг арав, эсвээс хорь, эсвээс тавь, эсвээс зуугаар нь олох хүртлээ ах дүүсийнхээ нутагт эргэж ирэх ёсгүй нь миний таалал бөлгөө.

31 Болгоогтун энэ бол миний таалал юм; асуу тэгвэл та нар хүлээн авах болно; гэвч хүмүүн миний тааллыг байнга хэрэгжүүлэх нь “үгүй.

32 Тиймийн тул, хэрэв та нар таван зууг олж үл чадах аваас, та нар магадгүй гурван зууг олж болохын тулд хичээнгүйлэн эрэлхийлэгтүн.

33 Мөн хэрэв та нар гурван зууг олж үл чадах аваас, та нар магадгүй нэг зууг олж болохын тулд хичээнгүйлэн эрэлхийлэгтүн.

34 Харин би үнэнээр та нарт хэлж байна, та нартай хамт Сионы нутаг өөд өгсөн очих миний өргөөний хүчин чадал болох нэг зууг олох хүртлээ Сионы нутаг өөд та нар явах ёсгүй хэмээх зарлигийг би та нарт өгч байна.

35 Тиймийн тул, би та нарт хэлсэнчлэн, асуу мөн та нар хүлээн авах болно; миний үйлчлэгч Бага Иосеф Смит магадгүй та нартай хамт явж, мөн миний хүмүүсийн дунд тэргүүлж, мөн “ариулан адислагдсан нутаг дээр миний хаант улсыг зохион байгуулж,

24a С ба Г 29:7–8;
45:64–66; 57:1–2.

26a С ба Г 97:22.

27a Мат. 10:39; Лук 9:24;

С ба Г 98:13–15;
124:54.

29a су Сидней Ригдон.

30a су Парлей, Пратт

Паркер.

б С ба Г 101:55.

31a С ба Г 82:10.

35a С ба Г 84:31.

мөн та нарт өгөгдсөн хийгээд өгөх хуулиуд мөн зарлигуудаар Сионы хүүхдүүдийг төлөвшүүлэхийн тулд шаргуу залбирагтун.

36 Та нарын “хичээл зүтгэл, итгэлтэй байдал мөн итгэлийн” залбирлуудаар дамжин бүх ялалт хийгээд алдар суу та нарт тохиохоор авчрагдаг болой.

37 Миний үйлчлэгч Парлей П.Пратт миний үйлчлэгч Бага Иосеф Смиттэй хамт аялаг.

38 Миний үйлчлэгч Лаймен

Вайт миний үйлчлэгч Сидней Ригдонтой хамт аялаг.

39 Миний үйлчлэгч Хайрум Смит миний үйлчлэгч Фредерик Г.Виллямстай хамт аялаг.

40 Миний үйлчлэгч Оорсон Хайд миний үйлчлэгч Оорсон Праттай хамт, та нарт миний өгсөн эдгээр зарлигуудын биелэлтийг хангахаар миний үйлчлэгч Бага Иосеф Смитийн тэдэнд зөвлөх тэр зүгт аялаг, мөн үлдсэнийг нь миний гарт үлдээг. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 104

1834 оны дөрөвдүгээр сарын 23-нд нэгдсэн журам буюу ядуусын ашиг тусын төлөөх Сүмийн журмын талаар бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 2:54–60). Уг үйл явдал нь хүмүүсийн тулгамдсан материаллаг хэрэгцээг авч хэлэлцсэн Тэргүүн Зөвлөлийн хийгээд бусад дээд санваартнуудын зөвлөлийн хурал байв. Көртланд дахь нэгдсэн журам түр хугацаанд татан буугдаж мөн дахин зохион байгуулагдаж, үйл ажиллагаанд ашиглагдаж байсан өмч хөрөнгө журмын гишүүдийн дунд хуваагдах ёстой байв.

1–10, Нэгдсэн журмын эсрэг зөрчил гаргасан Гэгээнтнүүд зүхэгдэх болно; 11–16, Их Эзэн Гэгээнтнүүдээ өөрийнхөө замаар хангадаг; 17–18, Сайн мэдээний хууль ядуусын төлөөх анхаарал халамжийг удирддаг; 19–46, Хэд хэдэн ах нарын ажил үүргүүд хийгээд адислалууд тогтоогдов; 47–53, Көртланд дахь нэгдсэн журам мөн Сион дахь нэгдсэн журам тус тусдаа үйл ажиллагаа явуулах ёстой; 54–66, Судруудыг хэвлэхийн тулд Их

Эзэний ариун сан хөмрөг бий болгогдов; 67–77, Нэгдсэн журмын ерөнхий сан хөмрөг нь нийтийн дэмжлэгийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулах ёстой; 78–86, Нэгдсэн журам дахь тэд өөрдийн бүх өрийг төлөх ёстой, мөн Их Эзэн тэднийг санхүүгийн эрхшээлээс чөлөөлөх болно.

Үнэнээр би та нарт хэлж байна, найз нар минь, зохион байгуулагдаж мөн үндэслэн байгуулагдаж, “нэгд-

сэн журам байхыг нь, мөн миний сүмийн ашиг тусын тулд мөн намайг ирэх хүртэл хүмүүний авралын тулд үүрдийн журам байхаар миний зарлигласан тэрхүү журамд хамрагдах бүх өмч хөрөнгийн талаар би та нарт зөвлөгөө, мөн нэг зарлиг өгч байна —

2 Миний зарлигласан тэд итгэлтэй байсныхаа хэрээр өөрчлөгдөшгүй мөн хувиршгүй амлалтаар, үй олон адислалаар адислагдах байсан буйза.

3 Гэвч тэд итгэлгүй байсныхаа хэрээр тэд зүхэлд ойрхон байлаа.

4 Тиймийн тул, миний үйлчлэгчдийн зарим нь зарлигийг сахьсангүй, харин “шунахай сэтгэлээр дамжуулан, мөн хуурмаг үгсээр гэрээг зөрчсөн билээ, бибээр тэднийг нэн зовлонтой хийгээд гашуудмаар зүхлээр зүхсэн болой.

5 Учир нь уг журамд харьяалагддаг ямар ч хүн зөрчил гаргагч болохын хэрээр, эсвээс, өөрөөр хэлбэл үгээр та нар үүрэг хүлээсэн гэрээг зөрчвөөс, тэрээр амьдралдаа зүхэгдэх болно, мөн миний хүссэн түүгээр дэвслэгдэх болно хэмээн Их Эзэн бибээр зүрх сэтгэлдээ тогтоосон билээ;

6 Учир нь Их Эзэн бибээр эдгээр зүйлүүдэд “шоглогдох ёсгүй —

7 Мөн энэ бүхэн бол та нарын дундах гэм зэмгүй нь, шударга бусчуудтай хамт буруутгагдахгүй байж болохын тулд болой; мөн та нарын дундах гэм буруутнууд зугтахгүй байж болохын тулд бөлгөө; учир нь Их Эзэн, бибээр өөрийн баруун гар талдахь сүр жавхлангийн “титмийг та нарт амласан билээ.

8 Тиймийн тул, та нар зөрчил гаргагчид болохын хэрээр, та нар амьдралдаа миний хилэгнэлээс зугтаж чадахгүй.

9 Зөрчлийн улмаас та нар “тусгаарлагдахын хэрээр, та нар гэтэлгэлийн өдөр хүртэл “Сатаны “тамлалаас зугтаж чадах нь үгүй.

10 Мөн хэрэв та нарын дундах, журмын аль ч хүмүүн зөрчил гаргагч болох нь мэдэгдэж, мөн хилэнцээсээ эс наманчлах аваас, та нар түүнийг Сатаны тамлалд өгч болох тэрхүү хүчийг яг энэ цагаас би та нарт өгч байна; мөн тэрээр та нар дээр азгүй явдлыг “авчрах хүчгүй байх болно.

11 Энэ нь надад орших мэргэн ухаан болой; тиймийн тул, та нар өөрсдийгөө зохион байгуулж мөн хүн болгоныг “ажил үүрэгт нь томил хэмээх зарлигийг би та нарт өгч байна;

12 Хүн болгон өөрт нь өгөгдсөн ажил үүргийнхээ тайланг

4а су Шунах.
6а Гал. 6:7–9;
7а Иса. 62:3;
С ба Г 76:56.

су Алдар суу.
9а су Сүмээс хөөх.
б су Чөтгөр.
в С ба Г 82:21.

10а С ба Г 109:25–27.
11а С ба Г 42:32.
су Даамал, Ажил
үүрэг.

миний өмнө өгч болохын тулд болой.

13 Учир нь Их Эзэн, бибээр хүн болгоныг амьд бүтээлүүдийнхээ тул миний хийж мөн бэлтгэсэн дэлхийн адислалуудын дээрх “даамал адил ^бхариуцлага хүлээдэг болгох ёстой ажгуу.

14 Их Эзэн, бибээр өөрийн “гарын бүтээл тэнгэрийг асарлаж, мөн дэлхийг ^ббүтээсэн билээ; мөн тэдгээр дэх бүх зүйл минийх болой.

15 Мөн өөрийн гэгээнтнүүдийг хангах нь миний зорилго болой, учир нь бүх зүйл минийх бөлгөө.

16 Харин энэ нь миний өөрийн “замаар хийгдэх ёстой нь шаардлагатай билээ; мөн болгоогтун энэ нь Их Эзэн, бибээр өөрийн гэгээнтнүүдийг хангаж ^бядуус өргөмжлөгдөж, үүнд баячууд дорд болгогдохоор миний тогтоосон зам юм.

17 Учир нь “дэлхий дүүрэн байна, мөн хангалттай бөгөөд нөөцлөхөөр буй; тийм ээ, бибээр бүх зүйлийг бэлтгэсэн, мөн өөрсдийнхөө төлөө ^бсонгогч байхыг нь хүмүүний үрст өгдөг билээ.

18 Гиймийн тул, хэрэв аливаа хүн миний хийснээс “элбэг дэлбэгээр авдаг бол, мөн миний сайн мэдээний

^бхуулийн дагуу “ядуус хийгээд гачигдагсадтай өөрийн хувийг хуваалцдаггүй бол, тэрээр, ёс бусчуудтай хамт “тамд нүдээ өргөн, тарчлалд байх болно.

19 Мөн эдүгээ, “журмын өмч хөрөнгийн талаар үнэнээр би та нарт хэлж байна —

20 Миний үйлчлэгч Сидней Ригдон эдүгээ оршин сууж байгаа тэр газраа мөн түүнд намайг зарлиглахад, бүр миний хүссэнээр миний талбайд хөдөлмөрлөхдөө дэмжигдэхийн тулд арьс боловсруулах үйлдвэрийн газрыг өөрийн ажил үүрэг байхаар тогтоог.

21 Мөн бүх зүйл журмын зөвлөгөө мөн нийтийн дэмжлэг буюу Көртландын нутаг дэвсгэрт амьдардаг журмын дуу хоолойны дагуу хийгддэг ёстой байг.

22 Мөн энэ ажил үүрэг хийгээд адислалыг Их Эзэн, бибээр өөрийн үйлчлэгч Сидней Ригдонд түүн дээрх, мөн түүний дараах үр удамд адислал болгон хүртгэж байна.

23 Мөн тэрээр миний өмнө даруу байхын хэрээр түүн дээрх адислалуудыг би өсгөн нэмэгдүүлэх болно.

24 Мөн дахин, өөрийн өмнөх өвийн тулд миний үйлчлэгч Жон Жонсон сольж авсан тэрхүү хэсэг газрыг миний

13а С ба Г 72:3–5, 16–22.

^б су Хариуцах,
Хариуцлага,
Хариуцлагатай.

14а Дуул. 19:1; 24:1.

^б Иса. 42:5; 45:12.

су Бүтээх, Бүтээл.

16а С ба Г 105:5.

су Халамж.

^б 1 Сам. 2:7–8;

Лук 1:51–53;

С ба Г 88:17.

17а С ба Г 59:16–20.

су Газар дэлхий.

^б су Сонгох эрх.

18а Лук 3:11;

Иаков 2:15–16.

^б С ба Г 42:30.

^в Сур. үгс 14:21;

Мозая 4:26;

С ба Г 52:40.

^г Лук 16:20–31.

19а су Нэгдсэн журам.

үйлчлэгч Мартин Харрис ажил үүрэгтээ өөртөө болон өөрийнхөө дараах үр удамдаа тогтоог.

25 Мөн тэрээр итгэлтэй байхын хэрээр түүн дээр мөн түүний дараах үр удам дээр бибээр адислалуудыг өсгөн нэмэгдүүлэх болно.

26 Мөн миний үйлчлэгч Мартин Харрис, миний үйлчлэгч Бага Иосеф Смитийн чиглүүлснээр миний үгсийг тунхаглахад мөнгөө зориулаг.

27 Мөн дахин, миний үйлчлэгч Фредерик Г.Виллямс эдүгээ өөрийн амьдарч байгаа газрыг аваг.

28 Мөн миний үйлчлэгч Оливер Каудери хэвлэх албаны тулд дугаар нэг бүхий хэсэг газар болох, уг байшингийн хажуу дахь тэр хэсэг газар тэрчлэн эцэг нь амьдарч байгаа тэр хэсэг газартай байг.

29 Мөн миний үйлчлэгчид Фредерик Г.Виллямс мөн Оливер Каудери нар хэвлэх алба мөн үүнд хамаарах бүх зүйлтэй байг.

30 Мөн энэ нь тэдэнд өгөгдөх ёстой ажил үүрэг нь байх болно.

31 Мөн тэд итгэлтэй байхын хэрээр, болгоогтун би адисалж, мөн тэдний дээр адислалуудыг өсгөн нэмэгдүүлэх болно.

32 Мөн энэ бол тэдний төлөө мөн тэдний дараах үр удмынх нь төлөө тэдэнд миний томилсон ажил үүргийн эхлэл бөлгөө,

33 Мөн, тэд итгэлтэй байхын хэрээр, би тэдэн дээрх мөн тэдний дараах үр удмынх нь дээрх адислалуудыг, бүр үй олон адислалыг өсгөн нэмэгдүүлэх болно.

34 Мөн дахин, миний үйлчлэгч Жон Жонсон өөрийн амьдарч байгаа тэр байшинтайгаа, мөн тэр өвтэйгөө, миний өргөөнүүд “барихын тулд нөөцөлсөн, уг өмчид хамаарах тэрхүү газраас бусад бүхэнтэй, мөн миний үйлчлэгч Оливер Каудерид нэрлэгдсэн тэдгээр газруудтай байг.

35 Мөн тэрээр итгэлтэй байхын хэрээр, би түүн дээр адислалуудыг өсгөн нэмэгдүүлэх болно.

36 Мөн миний гэгээнтнүүдийн хотыг барихын тулд тэмдэглэсэн газруудыг Сүнсний “дуу хоолойгоор түүнд мэдүүлэгдэхийн хэрээр, мөн журмын зөвлөгөөний, мөн журмын дуу хоолойны дагуу тэрээр зарах ёстой нь миний таалал бөлгөө.

37 Мөн энэ бол түүнд хийгээд түүний дараах үр удмынх нь адислалын тулд түүнд миний томилсон ажил үүргийн эхлэл билээ.

38 Мөн тэрээр итгэлтэй байхын хэрээр, түүн дээрх үй олон адислалыг би өсгөн нэмэгдүүлэх болно.

39 Мөн дахин, миний үйлчлэгч Ньюел К. “Витней эдүгээ өөрийн сууж буй байшингууд хийгээд газрыг, мөн худалдааны байгууламж

байгаа газар болон барилга, түүнчлэн худалдааны байгууламжийн өмнөд булан дахь газрыг, мөн тэрчлэн үнс боловсруулах газар байгаа тэрхүү газрыг ажил үүргийнхээ тулд өөртөө томилог.

40 Мөн түүн дээрх болон түүний дараах үр удмынх нь дээрх адислал болгон, Көртландын газар нутаг дахь миний гадасны тулд миний үндэслэн байгуулсан миний журмын худалдааны байгууламжийн ашиг тусын тулд энэ бүхнийг би өөрийн үйлчлэгч Ньюел К.Витнейд түүний ажил үүрэг байхаар тогтоосон билээ.

41 Тийм ээ, үнэнээр, энэ бол өөрийн үйлчлэгч Ньюел К.Витнейд түүнд өөрт нь болон түүний “төлөөний хүнд, мөн түүний дараах үр удамд нь миний тогтоож өгсөн ажил үүрэг, бүр худалдааны энэхүү бүхэл байгууламж буюу.

42 Мөн тэрээр өөрт нь миний өгсөн зарлигуудыг сахихад итгэлтэй байхын хэрээр, түүн дээр мөн түүний дараах үр удам дээр нь адислалуудыг, бүр үй олон адислалыг бибээр өсгөн нэмэгдүүлэх болно.

43 Мөн дахин, миний өргөө барихын тулд тэмдэглэсэн дөчин род урт, мөн арванхоёр род өргөн газрыг, мөн тэрчлэн эдүгээ эцгийнхээ

оршин суугаа өвийг миний үйлчлэгч Бага Иосеф Смит өөртөө томилог;

44 Мөн энэ бол түүн дээрх, мөн эцгийнх нь дээрх адислалын төлөө түүнд миний томилсон ажил үүргийн эхлэл бөлгөө.

45 Учрыг болгоогтун, би түүний “эцэгт зориулсан өвийг түүнийг дэмжихийн тулд нөөцөлсөн билээ; тиймийн тул тэрээр миний үйлчлэгч Бага Иосеф Смитийн гэр оронд тооцогдох болно.

46 Мөн бибээр өөрийн үйлчлэгч Бага Иосеф Смитийг итгэлтэй байхын хэрээр түүний гэр орон дээр адислалуудыг, бүр үй олон адислалыг өсгөн нэмэгдүүлэх болно.

47 Мөн эдүгээ, та нар үүнээс хойш гагцхүү дараах замаас бусдаар Сион дахь ах дүүстэйгээ нэгдсэн журмын хувьд холбогдохоо болино хэмээх Сионы талаарх нэг зарлигийг би та нарт өгч байна —

48 Та нар зохион байгуулагдсаныхаа дараа, Көртланд Хотын Сионы “Гадасны Нэгдсэн Журам хэмээн нэрлэгдэх ёстой. Мөн та нарын ахан дүүс, тэд зохион байгуулагдсаныхаа дараа, Сион Хотын Нэгдсэн Журам хэмээн нэрлэгдэх ёстой.

49 Мөн тэд өөрсдийнхөө нэрсээр мөн өөрсдийнхөө нэрэнд зохион байгуулагдах ёстой; мөн тэд ажлаа өөрс-

41a С ба Г 84:112–113.

45a С ба Г 90:20.

су Ахмад Иосеф

Смит.

48a С ба Г 82:13; 94:1;

109:59.

су Гадас.

дийн нэрэнд, мөн өөрсдийн нэрсээр явуулдаг байх ёстой;

50 Мөн та нар өөрсдийн нэрэнд мөн өөрсдийн нэрсээр ажлаа явуулах ёстой.

51 Мөн та нарын авралын тулд, мөн тэрчлэн тэдний авралын тулд, тэд “хөөгдөж байгаагийн, мөн ирэх ёстой тэр зүйлийн улмаас энэ нь хийгдэхийг би та нарт зарлиглалаа.

52 Зөрчил, “шунахай сэтгэл хийгээд хуурмаг үгсээр дамжин “гэрээнүүд зөрчигдөж буй —

53 Тиймийн тул, энэ цагийг эс тооцвол, та нар зээлээр тэдэнтэй гагцхүү энэ замаар холбогдохоос бусдаар, энэ журмаар зөвлөлд зөвшөөрөгдсөнчлөн, нөхцөл байдал та нарт боломж олгож, мөн зөвлөлийн дуу хоолой чиглүүлсэнчлэн, миний хэлсэнчлэн та нар ах дүүстэйгээ нэгдсэн журам байх чинь цуцлагдлаа.

54 Мөн дахин, та нарт миний томилсон ажил үүргийн тань талаар би та нарт нэг зарлиг өгье.

55 Болгоогтун, эдгээр бүх өмч хөрөнгө минийх билээ, эс бөгөөс та нарын итгэл хоосон зүйл, мөн та нар хоёр нүүртнүүд болой, мөн надтай хийсэн та нарын гэрээнүүд зөрчигдөх болой;

56 Мөн хэрэв өмч хөрөнгө минийх байх аваас, тэгвэл

та нар “даамлууд болно; эс бөгөөс та нар даамлууд биш болой.

57 Гэвч, үнэнээр би та нарт хэлье, би та нарыг өргөөний-хөө даамлууд, бүр жинхнээр даамлууд байхаар томиллоо.

58 Мөн энэ зорилгын учир өөрсдийгөө зохион байгуулахыг, бүр “миний үгсийг, миний судруудын бүрэн байдал, та нарт миний өгсөн, мөн үүнээс хойш цагаас цагт та нар миний өгөх илчлэлтүүдийг хэвлэхийг би та нарт зарлиглаж байна —

59 Миний сүмийг хийгээд дэлхий дээрх хаант улсыг байгуулах зорилгын төлөө, мөн бибээр өөрийн хүмүүстэй хамт “амьдрах нь, ойрхон байгаа тэр “цагт миний хүмүүсийг бэлтгэхийн тулд буюу.

60 Мөн та нар сан хөмрөгийн тулд, нэг байрыг өөрсдөдөө бэлтгэж, мөн үүнийг миний нэрэнд ариулан адислах ёстой.

61 Мөн та нар дундаасаа нэгнийг тэрхүү сан хөмрөгийг хадгалахаар томилох ёстой, мөн тэрбээр энэ адислалд томилогдох ёстой.

62 Мөн уг сан хөмрөг дээр лац байх ёстой, мөн бүх ариун зүйл тэрхүү сан хөмрөгт хүргэгдэх ёстой; мөн та нарын дундах аливаа хүн үүнийг, эсвээс үүний аль нэг хэсгийг өөрийнх хэмээн нэрлэх ёсгүй, учир нь энэ нь нэг эв эээр та

51a С ба Г 109:47.

52a су Шунах.

б су Гэрээ.

56a су Даамал, Ажил

үүрэг.

58a су Иосеф Смитийн Орчуулга (ИСО).

59a С ба Г 1:35–36;

29:9–11.

б су Мянган жил.

нарт бүгдэд харьяалагддаг байх ёстой.

63 Мөн би үүнийг та нарт яг энэ цагаас өгч байна; мөн эдүгээ та нар явж мөн та нарт миний томилсон ажил үүргийг үлэмж чухал ариун нандин зүйлүүдийг миний хэлсэнчлэн, эдгээр ариун нандин зүйлүүдийг хэвлэх зорилгын төлөө ашиглахын тулд, үүнийг анхаар.

64 Мөн тэрхүү ариун нандин зүйлүүдийн “ашиг тус нь эрдэнэсийн сан хөмрөгт байх ёстой, мөн үүн дээр лац байх ёстой; мөн журмын дуу хоолой, буюу зарлигаар бус аваас энэ нь хэн нэгнээр ашиглагдах буюу эрдэнэсийн сангаас гадагш аваачигдах ёсгүй, мөн үүн дээр байрлагдсан лац хөдлөх ёсгүй.

65 Мөн ийнхүү та нар сан хөмрөг дэх ариун нандин зүйлүүдийн ашиг тусыг ариун нандин хийгээд ариун зорилгын төлөө нөөцлөх ёстой.

66 Мөн энэ нь Их Эзний ариун нандин сан хөмрөг хэмээн нэрлэгддэг байх ёстой; мөн энэ нь ариун байж, мөн Их Эзэнд ариулан адислагдахын тулд үүн дээр лац тавигдах ёстой.

67 Мөн дахин, өөр нэг сан хөмрөг бэлтгэгдэх ёстой, мөн сан хөмрөгийг хадгалж байхын тулд, сангийн нярав томилогдох ёстой, мөн үүн дээр лац тавигдах ёстой.

68 Мөн ариун хийгээд ариун нандин зорилгуудын тул

миний өөртөө нөөцөлсөн ариун болоод ариун нандин бичээсүүдээс бусад, байшин барилгуудад, эсвээс газруудад, эсвээс малд, эсвээс бүх зүйлд та нарт миний өгсөн өмч хөрөнгийг сайжруулснаар өөрсдийн ажил үүргүүдэд та нарын олдог бүх мөнгийг хүлээж аваад аль болох түргэнээр зуутаар, тавьтаар, эсвээс хорьтоор, эсвээс аравтаар буюу тавтаар сан хөмрөгт хийх ёстой.

69 Эсвээс, өөрөөр хэлбэл, хэрэв та нарын дундах аль нэг хүн таван доллар олох аваас тэрээр үүнийг сан хөмрөгт хийг; эсвээс хэрэв тэрээр арвыг, эсвээс хорийг, эсвээс тавийг, эсвээс нэг зууг олох аваас, тэрээр мөн үүнчлэн үйлдэг;

70 Мөн та нарын дундах хэн нь ч энэ нь түүний өөрийнх хэмээн бүү хэлэг; учир нь энэ нь, мөн үүний аль ч хэсэг нь түүнийх хэмээн нэрлэгдэх ёсгүй.

71 Мөн үүний аль ч хэсэг нь журмын дуу хоолой хийгээд нийтийн дэмжлэгээр бус аваас ашиглагдах, эсвээс сан хөмрөгөөс гадагш авч явагдах ёсгүй.

72 Мөн та нарын дундах хэн нь ч сангийн няравт: Ажил үүрэгтээ туслахад минь надад үүнээс хэрэгтэй байна хэмээн хэлэхэд—энэ нь журмын дуу хоолой хийгээд нийтийн дэмжлэгээр байх болно—

73 Хэрэв энэ нь таван доллар

байх аваас, эсвээс энэ нь арван доллар, эсвээс хорь, эсвээс тавь, эсвээс нэг зуун доллар байх аваас сангийн нярав ажил үүрэгт нь түүнд туслах шаардлагатай тэр тооны мөнгийг түүнд өгөх болно—

74 Тэрээр гэм буруутан болох нь мэдэгдэж, мөн тэрээр итгэлтэй бус хийгээд “ухаалаг бус даамал болох нь журмын зөвлөлийн өмнө тодорхой үзүүлэгдэх хүртэл буюу.

75 Харин тэрээр бүрэн нөхөрлөлд байж, мөн ажил үүрэгтэй итгэлтэй хийгээд мэргэн бол, энэ нь уг сангийн нярав татгалзахгүй байхад түүний сангийн няравт үзүүлэх тэмдэг нь байх ёстой.

76 Харин зөрчлийн тохиолдолд, сангийн нярав нь зөвлөл хийгээд журмын дуу хоолойд захирагддаг байх ёстой.

77 Мөн сангийн нярав нь итгэлтэй биш хийгээд мэргэн биш даамал болох нь мэдэгдсэн тохиолдолд, тэрээр зөвлөл хийгээд журмын дуу хоолойд захирагддаг байх ёстой, мөн байрнаасаа шилжүүлэгдэх ёстой, мөн “өөр нэг нь түүний оронд томилогдох ёстой.

78 Мөн дахин, та нарын өрийн талаар үнэнээр би та нарт хэлж байна—болгоогтун, та нар бүх “өрөө ^бтөлөх нь миний таалал билээ.

79 Мөн та нар миний өмнө

өөрсдийгөө “даруусгаж, мөн өөрсдийн ^бхичээл зүтгэл болоод даруу төлөв байдал мөн итгэлийн залбирлаар энэхүү адислалыг олж авах нь миний таалал билээ.

80 Мөн та нар шаргуу хичээл зүтгэлтэй, мөн даруу төлөв байж, мөн итгэлийн “залбирлыг хөгжүүлэх тусам, болгоогтун, та нарын чөлөөлөлтийн төлөө бибээр та нарт арга хэрэгслийг илгээх хүртлээ та нарын өртэй тэдний зүрх сэтгэлийг би зөөлрүүлэх болно.

81 Тиймийн тул Нью-Йорк уруу яаралтай бичигтүн мөн миний “Сүнсээр хэлж өгөгдөх тэр зүйлийн дагуу бичигтүн; мөн та нар өртэй тэдний зүрх сэтгэлийг би зөөлрүүлж та нар дээр зовлон зүдгүүр авчрахаас тэдний оюун хол байлгагдах болно.

82 Мөн та нар “даруу төлөв хийгээд итгэлтэй байж мөн миний нэрийг дуудахын хэрээр, болгоогтун, би та нарт ^бялалтыг өгөх болно.

83 Та нар боолчлолоосоо ийнхүү нэгэнтээ чөлөөлөгдөхийн тулд би та нарт амлалт өгч байна.

84 Та нар хэдэн зуугаар нь, эсвээс хэдэн мянгаар нь бүр та нар өөрсдийгөө боолчлолоос чөлөөлөхөд хангалттайг зээлдэх хүртлээ мөнгө зээлдэх боломж олохын хэрээр,

74a Лук 16:1–12.

77a С ба Г 107:99–100.

78a су Өр.

б С ба Г 42:54.

79a су Даруу, Даруу

Байдал.

б су Хичээл зүтгэл.

80a Иаков 5:15.

81a су Ариун Сүнс.

82a Лук 14:11;

С ба Г 67:10.

б С ба Г 103:36.

энэ нь та нарын онцгой боломж байна.

85 Мөн ийнхүү нэгэнтээ, та нарын гарт миний тавьсан өмч хөрөнгийг өөрсдийн нэрсийг өгснөөр нийтийн дэмжлэгээр эсвээс өөр байдлаар, энэ нь та нарт сайн санагдсаанаар барьцаалагтун.

86 Би та нарт энэ онцгой боломжийг, ийнхүү нэгэнтээ

өгч байна; мөн болгоогтун, хэрэв та нарын өмнө миний тавьсан тэрхүү зүйлүүдийг хийхэд та нар миний зарлигуудын дагуу урагш ахих аваас, эдгээр бүх зүйл минийх бөлгөө, мөн та нар миний даамлууд болой, мөн эзэн нь байшингаа эвдэрсэн байхын зовлонг үл үзэх болно. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 105

1834 оны зургадугаар сарын 22-нд Миссурийн Фишинг Риверт Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 2:108–111). Миссури дэх Гэгээнтнүүдийн эсрэг танхайрагчдын бүлгийн харгис үйл ажиллагаа гаарав, мөн нилээд хэдэн гүнлэгийн зохион байгуулагдсан бүлгүүд хүмүүсийг устгах бодолтой байгаагаа зарлан мэдэгдэв. Сионы Хуаран хэмээн нэрлэгдсэн хэсгийг тэргүүлэн Бошиглогч хувцас хунар мөн хангамжийн зүйлс авчран Көртландаас хүрч ирэв. Энэ бүлэг хүмүүс Фишинг Риверт буудалласан үед Бошиглогч уг илчлэлтийг хүлээн авчээ.

1–5, Сион селестиел хуульд нийцэн баригдах болно; 6–13, Сионы гэтэлгэл багахан хугацаагаар хойшлогдов; 14–19, Их Эзэн Сионы тулалдаануудад тулалдах болно; 20–26, Гэгээнтнүүд мэргэн байж мөн тэд цугларах үедээ хүчирхэг ажлуудаараа сагсуурахгүй байх ёстой; 27–30, Жаксон болон хил залгаа гүнлэгүүдэд газрууд худалдан авагдах ёстой; 31–34, Көртланд дахь Их Эзэний гэрт ахлагч нар хишиг хүртэх ёстой; 35–37, Дуудагдсан болон сонгогдсон Гэгээнтнүүдийн аль аль нь ариусгагдах болно; 38–41, Гэгээнтнүүд энх тайвны тугийг дэлхийд өргөх ёстой.

ҮНЭНЭЭР би та нарт хэлж байна, зовж зүдэрсэн миний хүмүүсийн “гэтэлгэлийн талаарх миний тааллыг та нар мэдэж болохын тулд өөрсдийгөө хамтад нь цуглуулсан та нарт буюу —

2 Болгоогтун, би та нарт хэлнэ, хувь хүмүүсийн биш, харин сүмийн талаар ярихад, хэрэв миний хүмүүсийн “зөрчил байгаагүй сэн бол, тэд бүр эдүгээ гэтэлгэгдэж болох байсан билээ.

3 Гэвч болгоогтун, тэдний гараас миний шаардсан тэдгээр зүйлүүдэд тэд дуулгавартай байж сурсангүй, харин бүх төрлийн хилэнцээр

дүүрэн байна, мөн гэгээнтнүүд болсон үедээ өөрсдийн эд юмсаас ядуус хийгээд өөрсдийн дундах зовж зүдрэгсэдтэй “хуваалцахгүй байна;

4 Мөн селестиел хаант улсын хуулиар шаардагддаг эв нэгдлийн дагуу “нэгдээгүй болой;

5 Мөн энэ нь селестиел хаант улсын “хуулийн ^бзарчмуудаар биш бол, ^вСион байгуулагдаж чадах нь үгүй; эс тэгвээс бибээр үүнийг өөртөө хүлээн авч чадахгүй.

6 Мөн тэд “дуулгавартай байдлыг сурах хүртлээ миний хүмүүс, хэрэв энэ нь шаардагдах ёстой аваас, тэдний амсах тэр зүйлүүдээр ^бзэмлэгдэх ёстой нь шаардлагатай байна.

7 Миний хүмүүсийг удирдахаар томилогддог тэдний, миний сүмийн “анхны ахлагчид болох тэдний талаар би яриагүй байна, учир нь тэд бүгдээрээ энэхүү буруушаалт дор байгаа биш бөлгөө.

8 Харин хол байгаа сүмүүдийнхээ талаар би ярьж — Бурхан хаана байна вэ? Болгоогтун, тэр тэднийг гай зовлонгийн цагт чөлөөлөх болно, эс тэгвээс бид Сионд өгсөн очихгүй, мөн бид мөнгөө хадгалах болно хэмээн хэлэх нь олон буй.

9 Тиймийн тул, миний хүмүүсийн “зөрчлийн улмаас, миний ахлагчид Сионы гэтэлгэлийг багахан хугацаагаар хүлээх ёстой нь надад шаардлагатай байна —

10 Тэд өөрсдөө бэлтгэгдэхийн тулд, мөн миний хүмүүс илүү төгсөөр заалгаж, мөн туршлагатай болж, мөн өөрсдийн “үүрэг, мөн тэдний гараас миний шаарддаг зүйлүүдийн талаар илүү төгс мэдэхийн тулд буюу.

11 Мөн миний “ахлагчид тэнгэрийн хүчээр ^бхишиг хүртээгдэх хүртэл энэ нь улиран тохиохоор авчрагдаж чадахгүй бөлгөө.

12 Учрыг болгоогтун, тэд итгэлтэй байж мөн миний өмнө даруу төлөв байдалд үргэлжлүүлэхийн хэрээр агуу хишиг хийгээд адислал тэдэн дээр “юүлэгдэхээр би бэлтгэсэн билээ.

13 Тиймийн тул Сионы гэтэлгэлийн төлөө миний ахлагчид багахан хугацаагаар хүлээх ёстой нь надад шаардлагатай байна.

14 Учрыг болгоогтун, Сионы төлөө тулалдаануудад тулалдахыг би тэдний гараас шаардах нь үгүй; учир нь өмнөх зарлигтаа миний хэлсэнчлэн, бүр үүнийгээ би гүйцэлдүүлэх болно — та нарын

3а Үйлс 5:1–11;
С ба Г 42:30.
су Өргөл болгох,
Өргөлийн хууль.
4а С ба Г 78:3–7.
5а С ба Г 88:22.
б С ба Г 104:15–16.
в су Сион.

6а су Дуулгавартай
байх, Дуулгавар-
тай, Дуулгавартай
дагах.
б С ба Г 95:1–2.
су Зэмлэх, Зэмлэл.
7а С ба Г 20:2–3.
9а С ба Г 103:4.

10а су Үүрэг.
11а су Ахлагч.
б С ба Г 38:32; 95:8.
су Хишиг
(индаумент).
12а С ба Г 110.

тулалдаануудад би “тулалдах болно.

15 Болгоогтун, миний дайснуудыг устгаж мөн сүйрүүлэхээр миний урагш илгээсэн тэрхүү “устгагч буюу; мөн үүнээс хойш олон биш жилийн дараа тэд миний өвийг бузарлахаар, мөн өөрийн гэгээнтнүүдийг хамтад нь цуглуулахын тулд миний ^бариулан адисалсан газар нутаг дээр миний нэрийг “доромжлохоор үлдэх нь үгүй байх болно.

16 Болгоогтун, миний хүмүүсийн гэтэлгэлийн төлөө, мөн миний дайснуудын цамхгийг хурааж, мөн тэдний “харуулуудыг тараахын тулд, миний өргөөний ^бхүчин чадал болох бүр миний дайчдад, миний залуу эрчүүдэд мөн дунд насныханд хамтдаа цуглахыг хэл хэмээн би өөрийн үйлчлэгч Бага Иосеф Смитэд зарлигласан билээ.

17 Гэвч миний өргөөний хүчин чадал миний үгсийг анхаарсангүй.

18 Харин миний үгсийг тэд сонсохын хэрээр, хэрэв тэд итгэлтэй хэвээр байх аваас, адислал хийгээд “хишгийг би тэдний төлөө бэлтгэсэн билээ.

19 Би тэдний залбирлуудыг сонссон, мөн тэдний өргөлүүдийг хүлээн авах болно; мөн тэдний “итгэлийн сорилтын

учир тэд ийн хол авчрагдах ёстой нь надад шаардлагатай бөлгөө.

20 Мөн эдүгээ үнэнээр би та нарт хэлж байна, энд ирсэн болгоноос эргэн тойрны бүс нутгуудад үлдэж чадах тэд үлдэг хэмээх зарлигийг би та нарт өгч байна.

21 Мөн дорнодод гэр бүлтэй, үлдэж үл чадах тэд, миний үйлчлэгч Иосеф Смит тэдэнд томилохын хэрээр багахан хугацаагаар үлдэг;

22 Учир нь энэ асуудлын талаар би түүнд зөвлөх болно, мөн тэрээр тэдэнд томиллоо ч гэсэн, гүйцэлдэх болно.

23 Мөн эргэн тойрны бүс нутгуудад оршин суудаг миний бүх хүмүүс нэн их итгэлтэй, мөн залбиралтай, мөн миний өмнө даруу байг, мөн тэдгээр нь илчлэгдэх нь надад орших мэргэн ухаан болтол тэдэнд миний илчилсэн зүйлүүдийг бүү илчлэг.

24 Шүүлтүүдийн тухай бүү ярь, мөн итгэлээр ч, бас хүчирхэг ажлуудаар ч бүү “сагсуур, харин нэг бүс нутагт энэ нь байж болохын хэрээр хүмүүсийн санаа бодолд нийцсэн байдлаар болгоомжтойгоор хамтдаа цуглар.

25 Эдүгээ, болгоогтун, та нар хүмүүст: Хуулийн дагуу бидний төлөө шүүлт хийгээд шударга ёсыг гүйцэтгэж, мөн биднээс бурууг минь зайлуу-

14a Иош. 10:12–14;

Иса. 49:25;

С ба Г 98:37.

15a С ба Г 1:13–14.

б С ба Г 84:3–4; 103:35.

в С ба Г 112:24–26.

су Доромжлох,

Доромжлол.

16a су Харах, Харуул.

б С ба Г 101:55;

103:22, 30.

18a С ба Г 110:8–10.

19a су Итгэл.

24a С ба Г 84:73.

су Бардамнал.

лаач хэмээн хэлэх үедээ та нар “амар амгаланд, аюулгүйд үлдэж болохын тулд тэдний мэлмийд таалал хийгээд ач ивээлийг бибээр өгөх болно.

26 Эдүгээ, болгоогтун, би та нарт хэлнэ, найз нар минь, энэ замаар та нар Израилын “их цэрэг агуу их болох хүртэл хүмүүсийн мэлмийд тааллыг олж болох бөлгөө.

27 Миний үйлчлэгч Бага Иосеф Смит, мөн миний томилсон ахлагчид миний өргөөний хүчин чадлыг хуримтлуулах цагтай байх хүртэл “Фараоны зүрх сэтгэлийг зөөлрүүлж байсны адилаар би цагаас цагт хүмүүсийн зүрх сэтгэлийг зөөлрүүлэх болно,

28 Мөн Жаксон гүнлэгт мөн эргэн тойрны хил залгаа гүнлэгүүдэд “худалдан авч болох газрууыг худалдаж авах талаар миний зарлигласныг гүйцэлдүүлэх ^бмэргэн хүмүүсийг илгээхэд буюу.

29 Учир нь эдгээр газрууд худалдаж авагдах нь; мөн тэдгээр нь худалдан авагдсаны дараа миний гэгээнтнүүд миний өгсөн “өргөлийн хуулиудын дагуу тэдгээрийг эзэмших нь миний таалал билээ.

30 Мөн эдгээр газрууд худалдан авагдсаны дараа, өмнө нь тэд мөнгөөрөө худалдаж авсан өөрийнхөө газруудын өмчлөлийг авахад мөн тэдэн дээр ирж болох миний дайснуудын цамхгуудыг нураахад, мөн тэдний харуулуудыг тараахад, мөн намайг үзэн яддаг тэдний гурав дахь мөн дөрөв дэх үеийнхэнд миний “өс хонзонг авахад би Израилын ^бих цэргийг гэмгүй байлгах болно.

31 Харин эхлээд миний их цэрэг нэн агуу болог, энэ нь нар мэт гэрэлтэй, мөн “сар мэт тунгалаг, мөн тугнууд нь бүх үндэстнүүдэд сүрлэг байхын тулд энэ нь миний өмнө ^бариусгагдаг;

32 Сионы хаант улс бол чухамхүү үнэндээ бидний Бурханы хийгээд түүний Христийн “хаант улс мөн гэдгийг энэ дэлхийн хаант улсууд хүлээн зөвшөөрөхөөс аргагүйд хүрсэн байхад буюу; тиймийн тул, бүгдээрээ түүний хуулиудад ^бзахирагдагсад болцгооё.

33 Үнэнээр би та нарт хэлж байна, миний сүмийн анхны ахлагчид миний нэрээр Көртландын газар нутагт баригдахыг нь миний зарлигласан миний өргөөнд тэнгэрээс өөрсдийн “хишгийг хүлээн

25a су Амар амгалан.
26a Иоел 2:11.
27a Эхл. 47:1–12.
28a С ба Г 42:35–36.
б С ба Г 101:73.
29a С ба Г 42:30.
су Өргөл болгох,
Өргөлийн хууль;

Нэгдсэн журам.
30a С ба Г 97:22.
б С ба Г 35:13–14;
101:55; 103:22, 26.
31a Дуу. 6:10;
С ба Г 5:14; 109:73.
б су Ариусгал.
32a Илч. 11:15.

су Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс.
б су Засгийн газар.
33a С ба Г 95:8–9.
су Хишиг (индаумент).

авах ёстой нь надад шаардлагатай байна.

34 Түүний гэтэлгэлийн дараа Сионы талаар миний өгсөн зарлигууд мөн түүний “хууль гүйцэтгэгдэж мөн биелэгдэг.

35 “Дуудлагын өдөр байгаа хэдий ч сонголтын өдрийн тэрхүү цаг ирлээ; мөн ^бзохистой тэд сонгогдог.

36 Мөн “сонгогдсон тэд, Сүнсний дуу хоолойгоор миний үйлчлэгчид илэрхийлэгдэх болно; мөн тэд ^бариусгагдах болно;

37 Мөн тэд хүлээн авсан “зөвлөгөөгөө дагахын хэрээр, Сионд хамаарах бүх зүйлийг хэрэгжүүлэхэд, олон өдрийн дараа тэд хүчтэй байх болно.

38 Мөн дахин би та нарт хэлнэ, зөвхөн та нарыг цохьсон тэр хүмүүст төдийгүй мөн тэрчлэн бүх хүмүүст амар амгаланг уриал;

39 Мөн “энх амгалангийн ^бтугийг өргөж, мөн дэлхийн хязгааруудад амар амгаланг тунхаглагтун;

40 Мөн та нарыг цохьсон тэдэнд өөрсдөдөө байгаа Сүнсний дуу хоолойны дагуу амар амгалангийн саналуудыг дэвшүүл, мөн “бүх зүйл та нарын сайн сайхны төлөө хамтдаа ажиллах болно.

41 Тиймийн тул, итгэлтэй бай; мөн болгоогтун, мөн харагтун, бүр төгсгөл хүртэл би та нартай “хамт байна. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 106

1834 оны арваннэгдүгээр сарын 25-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 2:170–171). Энэхүү илчлэлт Оливер Каудерийн ах Варрен А.Каудерид чиглэгдсэн ажээ.

1–3, Варрен А.Каудери орон нутгийн тэргүүлэх ажилтнаар дуудагдав; 4–5, Хоёр дахь Ирэлт гэрлийн хүүхдүүд дээр хулгайч лугаа адил гэнэт ирэхгүй; 6–8, Агуу адислалууд Сүм дэх итгэлтэй үйлчлэгчдийг дагалддаг.

МИНИЙ үйлчлэгч Варрен А.Каудери, “Фридомын нутагт мөн эргэн тойрных нь бүс нутгуудад миний сүмийн дээрх тэргүүлэх дээд санваартнаар тохоогдож мөн томилогдох ёстой нь миний таалал болой;

34а ө.х. С ба Г 42-ийг Хууль хэмээн авч үздэг.

35а су Дуудах, Бурханаас дуудагдах, Дуудлага.

б су Зөв зохистой, Зөв

зохистой байдал.

36а С ба Г 95:5.

су Сонгох, Сонгосон, Сонгогдсон.

б су Ариусгал.

37а су Зөвлөгөө.

39а су Амар амгалан.

б су Туг.

40а Ром. 8:28;

С ба Г 90:24; 100:15.

41а Мат. 28:19–20.

106 1а ө.х. Эрх чөлөөний хот, Нью-Йорк болон орчны газрууд.

2 Мөн миний үүрдийн сайн мэдээг номлож, мөн зөвхөн өөрийнхөө газарт төдийгүй харин хил залгаа гүнлэгүүдэд дуу хоолойгоо өргөж мөн хүмүүсийг сэрэмжлүүлэх ёстой нь буюу.

3 Мөн энгээ түүнд миний өгч буй энэхүү дээд хийгээд ариун дуудлагад бүх цагаа зориулж, “тэнгэрийн хаант улсыг хийгээд үүний зөв шударга байдлыг ^бэрэлхийлэг, мөн зайлшгүй шаардлагатай бүх зүйл үүн дээр нэмэгдэн өгөгдөх болно; учир нь ^ахөдөлмөрлөгч хөлс шангаа авах нь зохистой бөлгөө.

4 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, Их Эзэний ^аирэлт ^бойртож байна, мөн энэ нь дэлхийд шөнийн ^ахулгайч лугаа адил ирэх болно.

5 Тиймийн тул, та нар ^агэрлийн хүүхдүүд байхын тулд, мөн тэр өдөр, хулгайч лугаа

адил та нар дээр ^бирэхгүйн тулд бүсээ бүслэгтүн.

6 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, миний үйлчлэгч Варрен миний очирт таягт мэхийж мөн хүмүүний зальхай ажлуудаас өөрийгөө тусгаарлахад тэнгэрт баясал болжээ;

7 Тиймийн тул, миний үйлчлэгч Варрен адислагдсан билээ, учир нь бибээр түүнд нигүүлсэлтэй байх бөлгөө; мөн түүний зүрх сэтгэлийн “хоосныг үл харгалзан, тэрээр миний өмнө өөрийгөө даруусгахын хэрээр би түүнийг өргөх болно.

8 Мөн үүгээр тэрээр тэсч гарахын тулд ^аач ивээл хийгээд итгэл найдварыг би түүнд өгөх болно; мөн хэрэв тэрээр итгэлтэй гэрч хийгээд сүмд гэрэл байхаа үргэлжлүүлэх аваас, миний Эцэгийн ^бхаршуудад түүнд зориулсан титмийг би бэлтгэсэн билээ. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 107

1835 оны гуравдугаар сарын 28-ны өдөр Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 2:209–217). Дурдсан өдөр Арванхоёр өөрсдийн хувь хүмүүсийн сул тал хийгээд дутагдлуудыг хүлээж, наманчлалыг илэрхийлж, Их Эзэнээс цаашидын удирдамж эрэлхийлж зөвлөлд хуралдав. Тэд томилогдсон дүүргүүд дэх номлолуудад салан хуваагдах гэж байв. Энэ хэсгийн зарим хэсэг дурдсан өдөр хүлээн авагдсан

<p>3а су Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс. б Мат. 6:33. в Мат. 10:10; С ба Г 31:5. 4а Иаков 5:8.</p>	<p>б су Эцсийн өдрүүд, Хожмын өдрүүд. в 1 Тес. 5:2. 5а су Гэрэл, Христийн гэрэл. б Илч. 16:15. 7а су Хоосон үг,</p>	<p>Хоосон үг ярих. 8а су Ач ивээл. б Иохан 14:2; Ифер 12:32–34; С ба Г 59:2; 76:111; 81:6; 98:18.</p>
--	---	---

хэдий ч зарим хэсэг нь өөр өөр үед, зарим нь бүр эрт, 1831 оны арваннэгдүгээр сард хүлээн авагдсаныг түүхийн цэдгүүд нотолдог.

1-6, Мелкизедек болон Аароны гэсэн хоёр санваар буй; 7-12, Мелкизедек санваарыг атгагч тэд Сүм дэх бүх албан тушаалд ажиллах хүчтэй байдаг; 13-17, Бишопын зөвлөл нь гаднах ёслолуудыг гүйцэтгэдэг Аароны санваарыг тэргүүлдэг; 18-20, Мелкизедек санваар нь сүнслэг бүх адислалын түлхүүрүүдийг атгадаг; Аароны санваар тэнгэр элчүүдийн тохинууллын түлхүүрүүдийг атгадаг; 21-38, Тэргүүн Зөвлөл, Арванхоёр мөн Дал нь, шийдвэрүүд нь эв нэгдэл хийгээд зөв шуударга ёсонд гаргагддаг байх ёстой тэргүүлэгч чуулгуудыг бүрдүүлдэг; 39-52, Патриархын ариун жаяг Адамаас Ноаг хүртэл бий болгогдов; 53-57, Эртний гэгээнтнүүд Адам-ондай-Аманд цуглаж, мөн Их Эзэн тэдэн дээр хүрч иржээ; 58-67, Арванхоёр нь Сүмийн ажилтнуудыг эмх цэгцэд тавих ёстой; 68-76, Бишопууд Израилын олон нийтийн шүүгчээр үйлчилдэг; 77-84, Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр нь Сүм дэх хамгийн дээд шүүх болдог; 85-100, Санваартны ерөнхийлөгчид тус тусын чуулгыг удирддаг.

СҮМД хоёр санваар, нэрлэвэл, “Мелкизедек болон ⁶Аароны, үүний дотор Левийн санваар буй.

2 Анхных нь Мелкизедек санваар хэмээн нэрлэгддэгийн учир нь “Мелкизедек бол ийм агуу дээд санваартан байсан бөлгөө.

3 Түүний өдрийн өмнө энэ нь Бурханы Хүүгийн “жаягийн нэрээр Ариун санваар хэмээн нэрлэгддэг байв.

4 Гэвч Агуу Нэгэний нэрийг хүндэтгэх буюу “эрхэмлэн хүндлэхээс үүдэн, түүний нэрийг хэтэрхий олон удаа давтахаас зайлсхийж, тэд, сүмийнхэн эрт дээр үед энэ санваарыг Мелкизедекийн нэрээр, эсвээс Мелкизедек санваар хэмээн нэрлэдэг байжээ.

5 Сүм дэх бусад бүх эрх мэдэл буюу албан тушаалууд нь энэ санваарын “хавсралтууд байдаг.

6 Гэвч хоёр ангилал буюу үндсэн төрөл байдгийн нэг нь Мелкизедек санваар, мөн нөгөөх нь Аароны буюу “Левийн санваар болой.

7 “Ахлагчийн албан тушаал нь Мелкизедек санваарын дор ирдэг бөлгөө.

8 Мелкизедек санваар нь ерөнхийлөн удирдах эрхийг атгадаг бөгөөд мөн дэлхийн бүх үед сүм дэх бүх албан тушаалд сүнсний зүйлүүдэд үйлчлэх хүч болон “эрх мэдэлтэй байдаг.

107 1a су Мелкизедек санваар.
б су Аароны санваар.
2a исо, Эхл. 14:25-40;
С ба Г 84:14.

су Мелкизедек.
3a Алма 13:3-19;
С ба Г 76:57.
4a су Хүндэтгэл.
5a С ба Г 84:29; 107:14.

6a Дэд хууль 10:8-9.
7a су Ахлагч.
8a су Эрх мэдэл.

9 Мелкизедекийн дэг жаягийн дагуу Дээд санваарын “Ерөнхийлөгчийн зөвлөл нь сүм дэх бүх албан тушаалд ажиллах эрхтэй байдаг.

10 Мелкизедек санваарын дэг жаягийн дагуу “дээд санваартнууд ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор сүнсний зүйлүүдийн тохиноулалд өөрсдийнхөө албан тушаалд, мөн тэрчлэн ахлагч, санваартан (Левийн жаягаар), багш, дикон, мөн гишүүний албан тушаалд ажиллах ^бэрхтэй байдаг.

11 Дээд санваартан байхгүй үед ахлагч нь түүний оронд ажиллах эрхтэй.

12 Дээд санваартан болон ахлагчид нь сүмийн гэрээнүүд хийгээд зарлигуудад нийцүүлэн сүнсний зүйлүүдэд үйлчлэх ёстой; мөн илүү дээд эрх мэдэлтнүүд байхгүй үед тэд сүмийн эдгээр бүх албан тушаалд ажиллах эрхтэй.

13 Хоёр дахь санваарыг “Аароны санваар гэдгийн учир нь ^бАарон болон түүний үр удамд энэ нь тэдний бүх үеийнхнээр дамжин олгогдож иржээ.

14 Энэ нь доод санваар хэмээн нэрлэгддэгийн учир гэвэл энэ нь дээд буюу Мелкизедек санваарын “хавсралт

байж, мөн гаднах ёслолуудыг гүйцэтгэх хүчтэй байдаг.

15 “Бишопын зөвлөл бол энэ санваартны ерөнхийлөгчийн зөвлөл бөгөөд мөн үүний түлхүүрүүд буюу эрх мэдлийг атгадаг.

16 Аароны “шууд удам байхаас бусдаар ямар ч хүн энэ албан тушаалд энэ санваарын түлхүүрүүдийг атгах хууль ёсны эрхгүй болой.

17 Харин Мелкизедек Санваарын дээд санваартан бүх доод албан тушаалуудад ажиллах эрх мэдэлтэй байдаг учраас тэрээр Мелкизедек санваартны “Ерөнхийлөгчийн зөвлөлийн гараар энэ хүчинд дуудагдаж мөн ^бонцгойлон адислагдах аваас Аароны шууд удмын хүн байхгүй газарт бишопын албан тушаалд ажиллаж болно.

18 Дээд буюу Мелкизедек санваарын хүч хийгээд эрх мэдэл нь сүмийн сүнсний бүх адислалуудын “түлхүүрүүдийг атгах нь болой—

19 Тэнгэрийн хаант улсын “нууцуудыг хүлээн авах онцгой боломжтой байх, тэнгэрийг тэдэнд нээлгэх, ^берөнхий хуралдай хийгээд Ууган Хүүгийн сүмтэй харьцах, мөн Бурхан Эцэг, мөн шинэ гэрээний “зууч Есүстэй харьцаж

9a С ба Г 81:2; 107:22, 65–67, 91–92.

10a су Дээд санваартан.

б С ба Г 121:34–37.

13a су Аароны санваар.

б су Аарон, Мосегийн ах.

14a С ба Г 20:52; 107:5.

15a су Бишоп.

16a С ба Г 68:14–21; 107:68–76.

17a С ба Г 68:15.

б су Томилох, Томилолт.

18a су Санваарын

түлхүүрүүд.
19a Алма 12:9–11;

С ба Г 63:23; 84:19–22.

су Бурханы нууцууд.

б Евр. 12:22–24.

в су Зууч.

мөн сэтгэл ханамжтай байх нь болой.

20 Доод буюу Аароны санваарын хүч хийгээд эрх мэдэл бол тэнгэр элчүүдийн тохиууллын “гүлхүүрүүдийг атгах, мөн гаднах ^бёслолууд, сайн мэдээний заавар, нүглүүдийн “ангжралын тулд наманчлалын ^вбаптисм, гэрээнүүд хийгээд зарлигуудад нийцүүлэн гүйцэтгэх нь болой.

21 Эдгээр хоёр санваарын хэд хэдэн албан тушаалд томилогдсон тэдний дундаас ерөнхийлөгчид, эсвээс тэргүүлэх ажилтнууд гарах нь хэрэгцээ бөлгөө.

22 “Мелкизедек санваартнуудын дундаас удирдлага нь сонгосон гурван ^бТэргүүлэх дээд санваартан тэрхүү албан тушаалд тохоогдож мөн томилогдон, мөн итгэл найдвар, итгэл бас сүмийн залбирлаар ^ддэмжигдэн Сүмийн Ерөнхийлөгчийн чуулгыг бий болгодог.

23 Аялагч “арванхоёр зөвлөх нь Арванхоёр ^бТөлөөлөгч, эсвээс бүх дэлхийд Христийн нэрний тусгай гэрчүүд байхаар дуудагддаг—ийнхүү дуудлагынхаа үүргүүдээр сүм дэх бусад ажилтнуудаас ялгардаг болой.

24 Мөн өмнө дурдсан гурван ерөнхийлөгчийн хүч хийгээд

эрх мэдэлтэй тэнцүү чуулгыг тэд бий болгодог.

25 “Дал нь мөн сайн мэдээг номлохоор мөн бүх дэлхий даяар харийнханд тусгай гэрчүүд байхаар дуудагддаг бөгөөд—ийнхүү дуудлагынхаа үүргүүдээр сүм дэх бусад ажилтнуудаас ялгардаг болой.

26 Мөн тэд Арванхоёр тусгай гэрч буюу дөнгөж саяхан нэрлэсэн Төлөөлөгчдийнхтэй адил тэгш эрх мэдэл бүхий чуулгыг бий болгодог.

27 Эдгээр чуулгуудын аль алиных нь гаргасан шийдвэр бүр мөн тэдний нэгдмэл дуу хоолойгоор байх ёстой; энэ нь тэд бие биентэйгээ нэгэн адил хүч хийгээд хүчин төгөлдөр байх шийдвэрүүд гаргахын тулд чуулга бүр дэх гишүүн болгон үүний шийдвэрүүдийг зөвшөөрсөн байх ёстой гэсэн үг юм—

28 Өөрөөр байх нь боломжгүйг нөхцөл байдал харуулсан үед олонх нь чуулгыг бий болгож болно—

29 Хэрэв энэ нь шалтгаан бус бол тэдний шийдвэрүүд нь Мелкизедекийн жаягийн дагуу томилогдсон, мөн зөв шударга хийгээд ариун эрчүүд байсан эртний гурван ерөнхийлөгчийн чуулгын шийдвэр болох адислалуудад эрхгүй болой.

30 Эдгээр чуулгуудын, эс-

20a С ба Г 13:1; 84:26–27.

б су Ёслолууд.

в су Нүглүүдийн ангжрал.

г су Баптисм,

Баптисм хүртээх.

22a су Мелкизедек

санваар.

б С ба Г 90:3, 6; 107:9, 65–67, 78–84, 91–92.

в су Сүмийн

удирдагчдыг

дэмжих.

23a С ба Г 107:33–35.

б су Төлөөлөгч.

25a су Дал.

вээс тэдгээрийн аль нэгнийх нь шийдвэрүүд бүхий л “зөв шударга ёсонд, цэвэр ариун байдалд, мөн дөлгөөн сэтгэлд, номхон дөлгөөн хийгээд тэвчээрт, мөн итгэлд, мөн “ариун журам, мөн мэдлэг, тэсвэр, хянуур байдал, бурханлиг чанар, ах дүүсэг ёсны нинжин сэтгэл хийгээд энэрэлд гаргагдах ёстой;

31 Амлалтын учир, хэрэв эдгээр зүйлүүд тэдгээрт элбэг дэлбэг байх аваас тэд Их Эзэний тухай мэдлэгт “үр жимсгүй байх нь үгүй байх болно.

32 Мөн эдгээр чуулгуудын аль ч шийдвэр нь зөв шударга бус байдалд хийгдсэн тохиолдолд энэ нь сүмийн сүнсний эрх мэдлүүдийг бүрдүүлдэг хэд хэдэн чуулгын хуралдайн өмнө авчрагдах ёстой; эс тэгвээс тэдний шийдвэрээс давж заалдах нь байж чадахгүй болгоо.

33 Арванхоёр нь сүмийг төлөвшүүлдэг, бүх үндэстэнд, эхлээд “харийнханд дараа нь иудейчүүдэд бүх хэрэг явдлыг зохицуулдаг Сүмийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлаган дор тэнгэрийн тогтсон ёс журамд нийцүүлэн Их Эзэний нэрээр үйл ажиллагаа явуулдаг Аялагч тэргүүлэгч дээд зөвлөл болой.

34 Дал нь “Арванхоёрын

буюу аялагч дээд зөвлөлийн удирдлаган дор сүмийг төлөвшүүлэхэд болон мөн үүний бүх хэрэг явдлыг бүх үндэстэнд, эхлээд харийнханд, мөн дараа нь иудейчүүдэд зохицуулахад Их Эзэний нэрээр үйлдэх ёстой.

35 Арванхоёр нь гадагш илгээгдэн, түлхүүрүүдийг атгаж, эхлээд харийнханд мөн дараа нь иудейчүүдэд Есүс Христийн сайн мэдээний тунхаглалаар хаалгыг нээх бөлгөө.

36 Сионы гадаснуудад байрладаг “дээд зөвлөлүүд сүмийн хэрэг явдлуудад, тэдний бүх шийдвэрт, ерөнхийлөгчийн чуулга, эсвээс аялагч дээд зөвлөлтэй эрх мэдлээрээ адил тэгш чуулгыг бий болгодог.

37 Сион дахь дээд зөвлөл нь сүмийн хэрэг явдлуудад, тэдний бүх шийдвэрт, Сионы гадаснууд дахь Арванхоёрын зөвлөлүүдтэй эрх мэдлээрээ адил тэгш чуулгыг бий болгодог.

38 Тэдэнд туслалцаа хэрэгтэй болсон үед сайн мэдээг номлон мөн үйлчлэхээр аливаа бусдын оронд хэд хэдэн дуудлагыг бөглөхөөр “Далыг дуудах нь аялагч дээд зөвлөлийн үүрэг болой.

39 Илчлэлтээр тэдэнд тогтоогдохын дагуу сүмийн бүх том салбаруудад “евангелийн

30a С ба Г 121:36.
су Зөв шударга,
Зөв шударга ёс.
б С ба Г 121:41.
су Нөлөөлөх хүч.
31a 2 Петр 1:5–8.

33a 1 Ниф. 13:42;
3 Ниф. 16:4–13;
С ба Г 90:8–9.
34a С ба Г 112:21.
36a су Дээд зөвлөл.
38a су Дал.

39a су Сургаал
номлогч;
Патриарх,
Патриархын.

тохинуулагчдыг томилох нь Арванхоёрын үүрэг болой—

40 Энэхүү санваарын жаяг нь эцгээс хүүд, мөн амлалтууд хийгдсэн, сонгогдсон үр удмын шууд удмынханд зүй ёсоор харьяалагдан доош гардуулагдаж байхаар үндэслэгдсэн болой.

41 Энэхүү жаяг нь “Адамын өдрүүдэд үндэслэгдэн бий болж, мөн дараах маягаар ^будмаар доош дамжуулагдан иржээ:

42 Адамаас, жаран есөн насандаа Адамаар томилогдож, мөн түүнийг (Адам) наснаас халихаас гурван жилийн өмнө түүгээр адислагдан, үр удам нь Их Эзэнээс сонгогдсон хүмүүс байж, мөн тэд дэлхийн төгсгөл хүртэл хамгаалагдах болно хэмээх Бурханы амлалтыг эцгээрээ хүлээн авсан “Сетэд болой;

43 Мөн гагцхүү насаараа л түүнээс ялгарч болох байсан учраас тэрээр (Сет) “төгс хүн байж, мөн түүний ^бтөрх байдал эцгийнх нь төрх байдлыг илэрхийлж, бүх зүйлд тэрээр эцэгтэйгээ адилхан санагдаж байв.

44 Енош нэг зуу гучин дөрвөн нас мөн дөрвөн сартайдаа, Адамын гараар томилогджээ.

45 Бурхан Кенаныг дөчин настайд нь аглаг буйдад дууджээ; мөн тэрээр Шедоламак

нутаг уруу аялж явахдаа Адамтай уулзжээ. Тэрээр томилолтоо хүлээн авахад наян долоон настай байлаа.

46 Махалалел, өөрийг нь тэрчлэн адисалсан Адамын гараар томилогдохдоо тэрээр дөрвөн зуу мөн ерэн зургаан жил мөн долоон өдрийн настай байлаа.

47 Жаред, тэрчлэн өөрийг нь адисалсан Адамын гар дор томилогдохдоо тэрээр хоёр зуун настай байжээ.

48 “Енох Адамын гар дор томилогдохдоо хорин таван настай байв; мөн түүнийг жаран тавтай байхад нь мөн Адам түүнийг адисалжээ.

49 Мөн тэрээр Их Эзэнийг харж, мөн түүнтэй хамт алхан, мөн түүний нүүрний өмнө үргэлж байв; мөн тэрээр Бурхантай хамт гурван зуун жаран таван жил “алхлан, тэрээр ^бзөөгдөх үедээ дөрвөн зуун гучин нас хүрсэн байлаа.

50 “Метусела, Адамын гар дор томилогдохдоо нэг зуун настай байв.

51 Ламех Сетийн гар дор томилогдохдоо тэрээр гучин хоёр настай байжээ.

52 “Ноа, Метуселагийн гар дор томилогдохдоо тэрээр арван настай байв.

53 Адам наснаас халихаас гурван жилийн өмнө тэрээр зөв шударга байсан түүний

41a су Адам.

^б Эхл. 5;

С ба Г 84:6–16;

Моце 6:10–25.

42a су Сет.

43a су Төгс.

^б Эхл. 5:3.

48a су Енох.

49a Эхл. 5:22; Евр. 11:5;

Моце 7:69.

^б су Зөөгдсөн

хүмүүн биес.

50a су Метусела.

52a су Моронай,

Мормоны хүү.

үр удмын үлдэгсдийн хамт бүгдээрээ “дээд санваартнууд болох Сет, Енош, Кенан, Махалалел, Иаред, Енох, мөн Метуселлаг ⁶Адам-ондай-Аманы хөндийд дуудаж, мөн тэнд сүүлчийнхээ адислалыг тэдэнд хүртээжээ.

54 Мөн Их Эзэн тэдэн дээр хүрч ирэн, мөн тэд босч, мөн “Адамыг адислан, мөн түүнийг ⁶Михаил, хунтайж, тэргүүн тэнгэр элч хэмээн нэрлэжээ.

55 Мөн Их Эзэн Адамд тайтгарлыг өгч, мөн түүнд хэлсэн нь: Бибээр чамайг тэргүүнд байхаар болголоо; олон үндэстэн чамаас ирэх болно, мөн чи тэдний дээр үүрд “хунтайж бөлгөө.

56 Мөн Адам цугларагсдын дунд зогсч байв; мөн тэрээр насны эрхээр бөгтийсөн хэдий ч, Ариун Сүнсээр дүүрэн байж, хожмын үеийнхний үр удамдаа тохиох юуг боловч “угтан хэлсэн бөлгөө.

57 Эдгээр зүйлүүд бүгдээрээ Енохын номонд бичигдсэн байлаа, мөн тогтоосон цагтаа гэрчлэгдэх ёстой болой.

58 Тэрчлэн дор өгүүлсэн илчлэлтийн дагуу сүмийн бусад бүх ажилтныг “томилж, мөн эмх цэгцэд тавих нь ⁶Арванхоёрын үүрэг юм:

59 Сионы нутаг дахь Христийн сүмд, түүнээс гадна сү-

мийн ажлын талаарх сүмийн нэмэлт “хуулиудад буюу —

60 Үнэнээр, би та нарт хэлж байна, ахлагчийн албан тушаалд байгаа тэднийг тэргүүлэхийн тулд “тэргүүлэгч ахлагчид байх ёстой нь шаардлагатай байна хэмээн Түмний Их Эзэн бибээр хэлж байна.

61 Мөн тэрчлэн санваартны албан тушаалынх болох тэднийг тэргүүлэх “санваартнууд буюу;

62 Мөн тэрчлэн багшийн албан тушаалынх болох тэднийг “тэргүүлэх багш нарыг, энэ маягаар, мөн тэрчлэн диконуудыг буюу —

63 Иймийн тул, Сүмийн гэрээнүүд хийгээд зарлигуудын дагуу диконоос багшид, мөн багшаас санваартанд, санваартнаас ахлагчид тэд тус тусдаа томилогддог бөлгөө.

64 Тэгээд бүхнээс дээд нь болох Дээд санваар ирдэг буюу.

65 Иймийн тул, санваарын дээр тэргүүлэхийн тулд Дээд санваартнаас нэг нь томилогдох ёстой нь шаардлагатай болой, мөн тэрээр Сүмийн дээд санваартны ерөнхийлөгч хэмээн дуудагдах ёстой;

66 Эсвээс, өөрөөр хэлбэл Сүмийн дээд санваартны дээрх “Тэргүүлэгч дээд санваартан буюу.

53a су Дээд санваартан.
 б С ба Г 78:15; 116:1.
 су Адам-ондай-Аман.
 54a С ба Г 128:21.
 су Адам.

б су Михаил.
 55a С ба Г 78:16.
 56a Мосе 5:10.
 58a су Томилох, Томилолт.
 б су Төлөөлөгч.
 59a С ба Г 43:2–9.

60a С ба Г 107:89–90.
 61a С ба Г 107:87.
 62a С ба Г 107:85–86.
 66a С ба Г 107:9, 91–92.
 су Ерөнхийлөгч.

67 Мөнхүү түүнээс гар “тавилтаар сүмийн дээрх ёслолууд хийгээд адисла-луудыг гүйцэтгэх нь ирдэг болой.

68 Иймийн тул, “бишопын албан тушаал нь үүнтэй адил тэгш биш бөлгөө; учир нь бишопын албан тушаал нь цаг зуурын бүх зүйлийг адислахад байдаг бөлгөө.

69 Гэсэн хэдий ч тэрээр Аароны “шууд удам биш аваас, бишоп нь дээд ^бсан-ваартнаас сонгогдох ёстой;

70 Учир нь хэрэв тэрээр Аароны шууд удмынх биш аваас тэрээр уг санваарын түлхүүрүүдийг атгаж чадахгүй.

71 Гэсэн хэдий ч, Мелкизедек-ийн жаягийн дагуу тэрхүү дээд санваартан нь үнэний Сүнсээр тэдгээрийн тухай мэдлэгтэй байж, материал-лаг зүйлүүдийн тохинуулалд онцгойлон адислагдаж болох бөлгөө.

72 Мөн тэрчлэн Израилд “шүүгч байж, сүмийн ажлыг явуулж, хуулиудын дагуу түүний өмнө тавигдах гэрч-лэл дээр сүмийн ахлагчдын дундаас өөрийн сонгосон буюу сонгох зөвлөхүүдийн-хээ туслалцаатайгаар зөрчил гаргагчдын дээрх шүүлтэд суух нь буюу.

73 Энэ бол Аароны шууд уд-мынх биш боловч, Мелкизе-декийн жаягаар дээд сан-

ваарт томилогдсон бишопын үүрэг болой.

74 Ийн тэрбээр шүүгч, бүр Сионы оршин суугчдын дун-дах эсвээс Сионы гадас дахь, эсвээс энэхүү тохинуулалд тэрээр онцгойлон адислагдах сүмийн аль ч салбарт, Сионы хил хязгаарууд өргөжсөн байж мөн Сионд эсвээс өөр газарт бусад бишопууд буюу шүүгчидтэй болох нь зайлш-гүй болох хүртэл олон ний-тийн шүүгч байх болно.

75 Мөн бусад бишопууд то-милогдохын хэрээр тэд мөн адил албан тушаалд ажиллах болно.

76 Харин Аароны шууд удам нь Мелкизедекийн жаягийн дагуу дээд санваартны ерөн-хийлөгч Израилын шүүгчээр сууж байгаагаас бусад тохиол-долд энэ санваарын ерөнхий-лөгчийн зөвлөлд, энэхүү тохинууллын “түлхүүрүүдэд, бишопын албан тушаалд зөв-лөхүүдгүйгээр бие даан үйл-дэх хууль ёсны эрхтэй бөлгөө.

77 Мөн эдгээр зөвлөлүү-дийн алиных нь ч шийдвэр нь доорхыг өгүүлэх зарли-гуудын дагуу болой:

78 Дахин, үнэнээр би та нарт хэлж байна, сүмийн хамгийн чухал ажил, мөн сүмийн хамгийн “хүнд хэрэг явдлууд нь бишопын буюу шүүгч-дийн шийдвэрийн талаар сэтгэл хангалуун биш байхын хэрээр, энэ нь сүмийн зөв-

67a су Гар тавих.

68a су Бишоп.

69a С ба Г 68:14–24;
84:18; 107:13–17.

б су Мелкизедек
санваар.

72a С ба Г 58:17–18.

76a су Санваарын

түлхүүрүүд.
78a С ба Г 102:13, 28.

лөлд, дээд санваарын ^берөнхийлөгчийн зөвлөлийн өмнө шилжүүлэгдэж мөн авчрагдах ёстой.

79 Мөн дээд санваартны зөвлөлийн ерөнхийлөгчийн зөвлөл нь бусад дээд санваартнууд, бүр арванхоёрыг зөвлөхүүд болгон туслуулахаар дуудах хүчтэй байх ёстой; мөн ийн дээд санваартны ерөнхийлөгчийн зөвлөл болон үүний зөвлөхүүд нь сүмийн хуулиудын дагуух гэрчлэл дээр шийдвэр гаргах хүчтэй байх болно.

80 Мөн энэ шийдвэрийн дараа энэ нь Их Эзэний өмнө дахин дурсагдахгүйн тулд байх ёстой; учир нь энэ нь Бурханы сүмийн хамгийн дээд зөвлөл мөн сүнсний хэрэг явдлуудаарх маргаанд эцсийн шийдвэр болох бөлгөө.

81 Сүмийн энэ зөвлөлөөс чөлөөлөгддөг сүмд харьяалагддаг ямар ч хүн гэж үгүй болой.

82 Мөн дээд санваартны ерөнхийлөгч зөрчил гаргахын хэрээр, тэрбээр дээд санваартны арванхоёр зөвлөхөөр туслуулах, сүмийн олон нийтийн зөвлөлийн өмнө шүүгдэхээр авчрагдах болно.

83 Мөн түүний талаарх тэдний шийдвэр нь түүний талаарх маргааныг төгсгөл болгох ёстой.

84 Ийнхүү бүх зүйл үнэн ба зөв шударга ёсны дагуу түүний өмнө дэг жаягт болон чанд байдалд хийгддэг байхын тулд хэн ч Бурханы “шүүх хийгээд хуулиудаас чөлөөлөгдөхгүй байх болно.

85 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, “диконы албан тушаалын дээрх ерөнхийлөгчийн үүрэг нь, гэрээнүүдийн дагуу өгөгдсөнчлөн арванхоёр диконы дээр тэргүүлэх, тэдэнтэй зөвлөлд суух, мөн тэдэнд үүргийг нь ^бзаах, бие биенээ сэнхрүүлэх нь болой.

86 Мөн тэрчлэн “багш нарын албан тушаалын дээрх ерөнхийлөгчийн үүрэг нь гэрээнүүдэд өгөгдсөнчлөн, хорин дөрвөн багшийн дээр тэргүүлэх, мөн тэдэнтэй зөвлөлд сууж, албан тушаалынх нь үүргүүдийг тэдэнд заах нь болой.

87 Тэрчлэн Аароны санваартны дээрх ерөнхийлөгчийн үүрэг нь гэрээнүүдэд өгөгдсөнчлөн дөчин найман “санваартны дээр тэргүүлэх, мөн тэдэнтэй зөвлөлд сууж, албан тушаалынх нь үүргүүдийг тэдэнд заах нь болой —

88 Энэхүү ерөнхийлөгч нь “бишоп байх ёстой; учир нь энэ бол энэхүү санваарын үүргүүдийн нэг билээ.

89 Дахин, “ахлагчдын албан

786 С ба Г 68:22.
84а су Шударга ёс.
85а су Дикон.
б С ба Г 38:23;

88:77–79, 118.
86а С ба Г 20:53–60.
су Багш, Аароны санваар.

87а су Санваартан, Аароны санваар.
88а су Бишоп.
89а су Ахлагч.

тушаалын дээрх ерөнхийлөгчийн үүрэг нь ерэн зургаан ахлагчийн дээр тэргүүлэх, мөн тэдэнтэй зөвлөлд сууж, мөн гэрээнүүдийн дагуу тэдэнд заах нь болой.

90 Энэхүү ерөнхийлөгчийн зөвлөл нь далынхаас ялгаатай бөгөөд бүх дэлхий даяар “аялдаггүй тэдний төлөө зориулагддаг болой.

91 Мөн дахин, дээд санваартны ерөнхийлөгчийн албан тушаалын үүрэг нь нийт сүмийн дээр “тэргүүлэх, мөн ^бМосетой адилхан байх явдал юм.

92 Болгоогтун, энэ нь мэргэн ухаан болой; тийм ээ, сүмийн тэргүүн дээр тэрбээр хүртээдэг Бурханы бүх ^абэлэгтэй байж, ^бүзмэрч, ^вилчлэгч, орчуулагч хийгээд ^гбошиглогч байх нь болой.

93 Мөн энэ нь “Далын дэг жаягийг харуулсан үзэгдлийн дагуу тэд далын гишүүдээс сонгогдсон өөрсдийнх нь дээр тэргүүлэх далан ерөнхийлөгчтэй байх ёстой;

94 Мөн эдгээр ерөнхийлөгчдийн долоо дахь ерөнхийлөгч нь зургаагийн дээр тэргүүлэх ёстой;

95 Мөн эдгээр долоон ерөн-

хийлөгч нь өөрсдийн харьяалагддаг анхны далаас гадна өөр далыг сонгох ёстой бөгөөд мөн тэдний дээр тэргүүлэх ёстой.

96 Мөн тэрчлэн, хэрэв талбай дахь шаардлагатай хөдөлмөр үүнийг шаардах аваас, долоо дахин дал болтол өөр далуудыг буюу.

97 Мөн эдгээр дал нь эхлээд харийнханд мөн тэрчлэн иудейчүүдэд “аялагч тохиуулагчид байх ёстой.

98 Арванхоёрт ч мөн Далд ч харьяалагддаггүй сүмийн бусад ажилтнууд бүх үндэстний дунд аялах хариуцлага дор байхгүй ч гэсэн, тэдний нөхцөл байдал боломж олгосон үед, тэд сүмд өндөр хийгээд хариуцлагатай албан тушаалуудыг эзэлж болно.

99 Иймийн тул, эдүгээ хүн бүр өөрийн “үүргийг мэдэж аваг, тэрээр томилогдсон албан тушаалдаа бүхий л ^бхичээл зүтгэлээр ажиллаг.

100 “Залхуу хойрго тэрээр ^бзохистойд үл тооцогдох бөлгөө, мөн үүргээ сурдаггүй мөн өөрийгөө нотлон харуулдаггүй тэрээр зохистойд үл тооцогдох ёстой. Бүр тийм буюу. Амен.

90а С ба Г 124:137.

91а С ба Г 107:9, 65–67.

б С ба Г 28:2;

103:16–21.

92а су Сүнсний

бэлгүүд.

б Мозая 8:13–18.

су Үзмэрч.

в су Илчлэлт.

г С ба Г 21:1.

су Бошиглогч.

93а С ба Г 107:38.

су Дал.

97а С ба Г 124:138–139.

99а су Үүрэг.

б су Хичээл зүтгэл.

100а С ба Г 58:26–29.

су Залхуурах,

Залхуу байдал.

б су Зөв зохистой,

Зөв зохистой

байдал.

ХЭСЭГ 108

1835 оны арванхоёрдугаар сарын 26-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 2:345). Энэхүү илчлэлт, өмнө нь дээд санваартнаар мөн далтнаар томилогдон мөн өөрийнхөө үүргийг мэдэж авах илчлэлт хүсч Бошиглогч дээр ирсэн Лайман Шерманы хүсэлтээр хүлээн авагджээ.

1–3, Лайман Шерман нүглүүдээсээ өршөөгдөв; 4–5, Тэрээр Сүмийн удирдах ахлагчдын дунд тоологдох ёстой; 6–8, Тэрээр сайн мэдээг номлох мөн өөрийн ах нарыг хүчирхэгжүүлэхээр дуудагдав.

ҮНЭНЭЭР, ийн Их Эзэн, чамд хэлж байна, миний үйлчлэгч Лайман: Миний томилсон түүний зөвлөгөөг хүлээн авахаар өнөө өглөө ийшээ хүрч ирэн миний дуу хоолойг чи дуулгавартай дагасан учир нүглүүд чинь чамд өршөөгдсөн болой.

2 Тиймийн тул, сүнслэг байдлынхаа тухайд сүнс чинь “амралтад байг, мөн миний дуу хоолойг хойшид бүү эсэргүүц.

3 Мөн босогтун мөн өөрийн хийсэн мөн хийх тангаргуудыг анхааралтай дагахад энэ цагаас хойш илүү анхааралтай байгтун, мөн чи үлэмж агуу адислалуудаар адислагдах болно.

4 Миний үйлчлэгчдээс “онцгой ариун хуралдай дуудагдах хүртэл тэвчээртэйгээр хүлээгтүн, тэгээд чи миний анхны ахлагчдын дунд дурсагдах болно, мөн миний сонгосон ахлагчдын үлдсэний хамт томилолтоор эрх хүлээн авах болно.

5 Болгоогтун, хэрэв чи итгэлтэй хэвээр үлдэх аваас, энэ нь чамд өгөх Эцэгийн “амлалт бөлгөө.

6 Мөн энэ нь үүнээс хойш энэ цагаас би чамайг хааш нь ч илгээлээ гэсэн чи миний сайн мэдээг “номлох эрхтэй байх тэр өдөр чам дээр гүйцэлдэх болно.

7 Тиймийн тул, бүх яриа, бүх залбирлууд, бүх ухуулгууд, мөн бүх үйлүүддээ ах нараа “хүчирхэгжүүлэгтүн.

8 Мөн болгоогтун, мөн харагтун, бибээр чамайг адислахаар мөн чамайг “чөлөөлөхөөр чамтай үүрд хамт байна. Амен.

ХЭСЭГ 109

1836 оны гуравдугаар сарын 27-нд Огайогийн Көртландад ариун сүмийг онцгойлон адислахад хийсэн залбирал оршвой (History of

108 2а су Амрах.
4а С ба Г 109:6–10.

5а С ба Г 82:10.
6а су Номлолын ажил.

7а Лук 22:31–32.
8а 2 Ниф. 9:19.

the Church, 2:420–426). Бошиглогчийн бичгээр гаргасан нотолгоогоор бол, энэ залбирал түүнд илчлэлтээр өгөгджээ.

1–5, Көртландын Ариун Сүм Хүний Хүүгийн айлчлах газар болон баригдсан байлаа; 6–21, Энэ нь залбирлын, мацгийн, итгэлийн, суралцахын, алдар суугийн мөн дэг жаягийн өргөө, мөн Бурханы өргөө байх ёстой; 22–33, Их Эзэний хүмүүсийг эсэргүүцдэг үл наманчлагчид шившиглэгдэх болтугай; 34–42, Гэгээнтнүүд зөв шударгыг үйлдэгчдийг Сионд цуглуулах хүчинд урагш одох болтугай; 43–53, Эцсийн өдрүүдэд ёс бусчууд дээр юүлэгдэх аймшигт зүйлүүдээс Гэгээнтнүүд чөлөөлөгдөх болтугай; 54–58, Үндэстнүүд хийгээд хүмүүс мөн сүмүүд сайн мэдээний төлөө бэлтгэгдэх болтугай; 59–67, Иудейчүүд, леменчүүд, мөн бүх Израил гэтэлгэгдэх болтугай; 68–80, Гэгээнтнүүд алдар суу хийгээд хүндэтгэлээр титэмлэгдэж мөн мөнхийн авралыг олох болтугай.

ТАНЫ өмнө бүх зүрх сэтгэлээрээ цэх шулуун алхдаг өөрийн үйлчлэгчидтэй “гэрээг сахьж мөн нигүүлслийг үзүүлдэг, Ай Израилын Бурхан, Их Эзэн таны нэрэнд ^бталархал байх болтугай.

2 Энэ газарт [Көртланд] өөрийн нэрэнд өргөөг “барихаар үйлчлэгчиддээ зарлигласан тэр нь та билээ.

3 Мөн эдүгээ Ай Их Эзэн та, үйлчлэгчид тань таны зарлигийн дагуу хийснийг болгоогтун.

4 Мөн эдүгээ аврал дангаараа түүний нэрээр хүмүүний үрсэд өгөгдөж болох, таны цээжний Хүү, Есүс Христийн нэрээр, Ариун Эцэг танаас бид гуйж байна, Ай Их Эзэн минь, таны үйлчлэгчид бидний “гарын бүтээл, барихыг нь та бидэнд зарлигласан энэхүү ^бөргөөг соёрхон хүлээж авахыг бид гуйж байна.

5 Учир нь агуу их гай зовлон үзэж байж энэ ажлыг хийснийг та мэдэх билээ, Хүний Хүү өөрийнхөө хүмүүст өөрийгөө үзүүлж болох газартай байж болохын тулд бид ядуу зүдүү байдлаасаа өөрсдийн эд хөрөнгийг таны нэрэнд “өргөө барихад өргөсөн билээ.

6 Мөн та бидэнд өгсөн нэгэн “илчлэлтэд биднийг найз нараа хэмээн дуудаж, хэлэхдээ — Та нарт миний зарлигласанчлан, өөрсдийн онцгой ариун хуралдайг дуудагтун гэсэн билээ;

7 Мөн бүгдээрээ итгэлгүй байгаа болохоор, та нар мэргэн ухааны үгсийг хичээнгүйлэн эрэлхийлж мөн бие биендээ заагтун; тийм ээ,

109 1a Дан. 9:4.
су Гэрээ.
б Алма 37:37;
С ба Г 46:32.
су Талархалтай,

Талархах, Талархал
өргөх.
2a С ба Г 88:119.
4a 2 Ниф. 5:16.
б Хаад. дээд 9:3.

су Ариун Сүм, Их
Эзэний Өргөө.
5a С ба Г 124:27–28.
6a С ба Г 88:117–120.

мэргэн ухааны үгсийн шилдэг номнуудаас та нар эрэлхийл, бүр сурахаар мөн тэрчлэн итгэлээр суралцахыг эрэлхийл;

8 Өөрсдийгөө зохион байгуул; хэрэгтэй юм болгоныг бэлтгэ, мөн өргөө, бүр залбирлын өргөө, мацгийн өргөө, итгэлийн өргөө, суралцахын өргөө, алдар суугийн өргөө, дэг жаягийн өргөө, Бурханы өргөө байгуул;

9 Та нарын оролтууд Их Эзэний нэрэнд байж болохын тулд, та нарын гаралтууд Их Эзэний нэрэнд байж болохын тулд, та нарын бүх мэндчилгээнүүд Их Эзэний нэрэнд, Бүхнээс Дээдэд өргөсөн гарын хамт байж болохын тулд буюу.

10 Мөн эдүгээ, Ариун Эцэг минь, таны алдар хүндэтгэл хийгээд таны бурханлиг хүлээн зөвшөөрөлтөд үйлдэгдэж болохын тулд өөрийнхөө хүмүүс бидэнд онцгой ариун хуралдайг дуудахад ач ивээлээрээ туслахыг бид танаас гуйж байна;

11 Мөн бид таны мэлмийд зохистой байж болохын тулд, таны хүмүүс, бидэнд өгөгдсөн илчлэлтүүдэд таны өгсөн “амлалтуудын биелэлтийг олж авах тэрхүү маягт буюу;

12 Таны “алдар суу доош таны хүмүүс дээр, мөн эдүгээ бид танд зориулан онцгойлон адисалж буй таны энэ өргөөн дээр амарч болохын тулд, энэ нь ариун байхын

тулд ариусгагдаж мөн ариулан адислагдахын тулд, мөн таны ариун оршихуй энэ өргөөнд цаг ямагт байж болохын тулд буюу.

13 Мөн Их Эзэний өргөөний хатавчаар орж ирэх бүх хүмүүс таны сүр хүчийг мэдэрч болохын тулд, мөн та үүнийг ариусгасныг аргагүйн эрхэнд хүлээн зөвшөөрөхөд хүрч болохын тулд, мөн энэ нь таны өргөө, таны цэвэр ариун байдлын газар байхын тулд буюу.

14 Мөн Ариун Эцэг минь, энэ өргөөнд шүтэн бишрэх тэд бүгд шилдэг номнуудаас мэргэн ухааны үгсээр заагдаж болохын тулд таны хэлсэнчлэн мөн тэд бүр сурахаар мөн тэрчлэн итгэлээр суралцахыг эрэлхийлж болохын тулд буюу;

15 Мөн тэд танд өсөхийн тулд, мөн Ариун Сүнсний бүрэн байдлыг хүлээн авч, мөн таны хуулиудын дагуу зохион байгуулагдаж, мөн хэрэгтэй юм болгоныг олж авахад бэлтгэгдэж болохын тулд буюу;

16 Мөн энэ өргөө залбирлын өргөө, мацгийн өргөө, итгэлийн өргөө, алдар суугийн болон Бурханы өргөө, бүр таны өргөө байж болохын тулд буюу;

17 Таны хүмүүсийн бүх оролтууд, энэ өргөөнд Их Эзэний нэрэнд байж болохын тулд буюу;

18 Энэ өргөөнөөс гарах

тэдний бүх гаралтууд Их Эзэний нэрэнд байж болохын тулд буюу;

19 Мөн тэдний бүх мэндчилгээ Их Эзэний нэрэнд, Бүхнээс Дээдэд өргөсөн ариун гарын хамт байж болохын тулд буюу;

20 Мөн “цэвэр ариун биш зүйл үүнийг бохирлохоор таны өргөөнд орох нь зөвшөөрөгдөхгүй байж болохын тулд буюу;

21 Мөн таны хүмүүсийн хэн нь ч зөрчил гаргахад, тэд нэн түргэнээр наманчилж мөн танд эргэн ирж мөн таны мэлмийд ээл хишгийг олж, мөн таны өргөөнд таныг “хүндэтгэн бишрэх тэдэн дээр юүлэгдэхээр таны томилогдсон адислалуудад сэргээгдэж болохын тулд буюу.

22 Мөн Ариун Эцэг минь, таны үйлчлэгчид энэ өргөөнөөс таны сүр хүчээр зэвсэглэн урагш одож болохын тулд, мөн таны нэр тэдэн дээр байж болохын тулд мөн таны алдар суу тэдний эргэн тойронд байж болохын тулд, мөн таны “тэнгэр элчүүд тэдний дээр захирч байхын тулд бид танаас гуйж байна.

23 Мөн энэ газраас тэд үлэмж агуу хийгээд алдар суут мэдээг үнэнд, дэлхийн “хязгааруудад хүргэж болохын төлөө, энэ бол таны ажил гэдгийг, мөн эцсийн өдрүүдийн талаар бошиг-

логчдын амаар, та өөрийнхөө ярьсныг гүйцэлдүүлэхийн тулд та гараа урагш тавьсан юм гэдгийг тэд мэдэж болохын тулд буюу.

24 Ариун Эцэг минь, бишрэн шүтдэг, мөн таны энэхүү өргөөнд бүх үеийнхэнд мөн үүрд мөнхөд нэр алдрыг хүндтэйгээр хадгалж мөн зогсдог хүмүүсийг төлөвшүүлэхийг бид танаас гуйж байна;

25 Тэдний эсрэг “бий болсон ээр зэвсэг амжилтад хүрэхгүй байхыг; тэдэнд зориулж ⁶нүх ухдаг тэрээр мөн үүндээ өөрөө унахыг буюу;

26 Ёс бусын нэгдэл өндийн босч мөн энэ өргөөнд таны “нэр тэдэн дээр тавигдах хүмүүсийн тань дээр ⁶дийлэх хүчгүй байхыг буюу;

27 Мөн хэрэв ямар ч хүмүүс энэ хүмүүсийн эсрэг босох аваас, таны уур тэдний эсрэг дүрэлзэхийн тулд буюу;

28 Мөн хэрэв тэд энэ хүмүүсийг цохих аваас, та тэднийг цохих болно; тэд бүх дайсныхаа гараас чөлөөлөгдөж болохын тулд тулалдааны өдөрт та ингэдэгчлэн, та өөрийнхөө хүмүүсийн төлөө тулалдах ажаамуу.

29 Ариун Эцэг минь, таны үйлчлэгч буюу үйлчлэгчдийн эсрэг худал үгсийг алс хол дэлхий даяар тараасан тэд бүгдийг, хэрэв тэд үүрдийн сайн мэдээг чихэнд нь тун-

20a С ба Г 94:8–9;
97:15–17.

21a су Хүндэтгэл.

22a су Тэнгэр элчүүд.

23a С ба Г 1:2.

25a Иса. 54:17.

⁶ Сур. үгс 26:27;

1 Ниф. 14:3; 22:14.

26a Хаад. дээд 8:29.

⁶ С ба Г 98:22.

хаглахад эс наманчлах аваас, шившиглэж, мөн гайхахад хүргэн, мөн ичгүүрт хийгээд тодорхой бус байдалд авчрахыг бид танаас гуйж байна;

30 Мөн тэдний бүх ажил юу ч бишид авчрагдаж, мөн “мөндрөөр, мөн уурандаа тэдэн дээр таны илгээх шүүлтүүдээр арчигдахын тулд, таны хүмүүсийн эсрэг ^бхудал үгс хийгээд гүтгэлэгт төгсгөл байхын тулд буюу.

31 Учир нь та мэдэх билээ, Ай Их Эзэн минь, таны үйлчлэгчид нэрийг тань гэрчлэхэд таны өмнө гэм буруугүй билээ, үүний төлөө тэд эдгээр бүх зүйлийг тэвчсэн болой.

32 Тиймийн тул, энэ “буулган дороос бүрэн хийгээд төгс чөлөөлөгдөхийг бид таны өмнө гуйж байна;

33 Ай, Их Эзэн минь, үүнийг эвдэж хаяач; бид энэ үеийнхний дунд босч, мөн таны ажлыг хийж болохын тулд үүнийг үйлчлэгчдийнхээ хүзүүнээс өөрийн хүчээр эвдэж хаяач.

34 Ай, Иехова, энэ хүмүүсийн дээр нигүүлсэлтэй байгаач, мөн бүх хүмүүн “нүглийг үйлддэг учир, өөрийн хүмүүсийн зөрчлийг өршөөгөөч, мөн тэдгээрийг үүрд арилгагдахаар болгооч.

35 Тохинуулагчдын тань “томилолт тэнгэрийн хүчээр тэдэн дээр лацдагдаг.

36 Энэ нь Пентекостын өдөр тэдэн дээр байхын адилаар тэдэн дээр гүйцэлдэг; таны хүмүүс дээр бүр галынх мэт “салаалсан хэлний, мөн үүний хөрвүүлгийн адил ^бхэлний бэлэг юүлэгдэг.

37 Мөн таны өргөө хуйлрах хүчит салхи лугаа адил таны “алдар суугаар дүүргэгдэг.

38 Тэд гадагш одож мөн таны үгсийг тунхаглахдаа тэд “хуулийг лацдан, мөн та хилэгнэлдээ ^бдэлхийн оршин суугчид дээр тэдний зөрчлийн улмаас илгээх гэж буй тэдгээр бүх шүүлтийн тулд өөрийн гэгээнтнүүдийн зүрх сэтгэлийг бэлтгэх, гай зовлонгийн өдөрт таны хүмүүс унахгүйн тулд, гэрээний ^бгэрчлэлийг үйлчлэгчид дээрээ тавиац.

39 Мөн таны үйлчлэгчид ямар ч хотод орлоо гэсэн, тэр хотын хүмүүс тэдний гэрчлэлийг хүлээн авахад тэд тэр хотоос зөв шударгыг үйлдэгчдийг цуглуулж болохын тулд, тэд “Сион уруу, эсвээс түүний гадаснууд уруу үүрдийн баяслын дуунуудтайгаар ирж болохын тулд таны амар амгалан хийгээд таны аврал тэр хот дээр байг;

40 Мөн энэ нь биелэгдэх

30a Иса. 28:17;
Мозая 12:6;
С ба Г 29:16.
б 3 Ниф. 21:19–21.
32a су Буулга.
34a Ром 3:23; 5:12.

су Нүгэл.
35a су Томилох.
36a Үйлс 2:1–3.
б су Хэлний бэлгүүд.
37a С ба Г 84:5; 109:12.
су Алдар суу.

38a Иса. 8:16; С ба Г 1:8.
б су Дэлхий—
Дэлхийн
цэвэршилт.
в су Гэрчлэл.
39a Иса. 35:10.

хүртэл таны шүүлтүүд тэр хот дээр бүү бууг.

41 Мөн таны үйлчлэгчид ямар ч хотод орлоо гэсэн, мөн тэр хотын хүмүүс таны үйлчлэгчдийн гэрчлэлийг хүлээн авахгүй бол, мөн энэ зөрүүд үеийнхнээс тэд өөрсдийгөө аврахыг таны үйлчлэгчид тэдэнд сэрэмжлүүлэг, бошиглогчдынхоо амаар таны ярьсны дагуу энэ нь тэр хот дээр байг.

42 Харин Ай Иехова та өөрийн үйлчлэгчдийг тэдний гараас чөлөөлж, мөн тэдний цуснаас тэднийг цэвэрлээч хэмээн бид гуйж байна.

43 Ай Их Эзэн минь, нөхдийг маань устгаж байгаад бид баярлах нь үгүй; тэдний “бодгалиуд таны өмнө үнэ цэнэтэй бөлгөө.

44 Гэвч таны үг гүйцэлдэх ёстой. Биднийх бус, харин Их Эзэн таны таалал гүйцэлдэх болно хэмээн хэлэхэд нь тэдэнд “ач ивээлээрээ дэм үзүүлэн өөрийн үйлчлэгчдэд туслаач.

45 “Эцсийн өдрүүд дэх ёс бусчуудын талаарх аймшигт зүйлүүдийг та бошиглогчдынхоо амаар ярьсныг, — та хэмжээлшгүй шүүлтүүдээ юүлэх болно гэдгийг бид мэднэ;

46 Тиймийн тул, Ай Их Эзэн минь, өөрийн хүмүүсийг ёс бусчуудын гай түйтгэрээс чөлөөлөөч; тэд шатаалтын өдөрт бэлтгэгдэхийн тулд

хуулийг лацдаж мөн гэрчлэлийг битгүүмжлэх боломжийг өөрийн үйлчлэгчдэд олгооч.

47 Ариун Эцэг минь, Миссурин Жаксон гүнлэгийн оршин суугчдаар өвийнхөө нутгуудаас хөөгдсөн тэднийг санаач, мөн тэдэн дээр тавигдсан зовлон зүдгүүрийн буулгыг эвдэж хаяач, Их Эзэн минь.

48 Тэд ёс бус хүмүүсээр туйлын ихээр доромжлуулж мөн зовлон зүдгүүрт унасныг та мэдэх билээ Ай Их Эзэн минь; тэдний хүнд хэцүү ачааны улмаас бидний зүрх сэтгэл уй гашууд “автнам.

49 Энэ хүмүүс энэ гай зовлон зүдгүүрийг үүрэхийг, мөн гэм зэмгүй тэдний хашгиралтууд дээшээ таны сонорт хүрэхийг, мөн тэдний “цус таны өмнө гэрчлэлд очихыг, мөн тэдний тусын тулд өөрийн гэрчлэлийг харуулахгүйгээр та “хичнээн удаан тэвчих юм бэ, Ай Их Эзэн минь?

50 Тэд эвдэн сүйтгэхээ зогсоож болохын тулд, хэрэв наманчлал байх аваас, тэд нүглүүдээсээ наманчилж болохын тулд таны хүмүүсийг хөөсөн ёс бус танхайрагчдын бүлгийн хувьд “нигүүлсэлтэй байгаач Ай Их Эзэн минь;

51 Харин хэрэв тэд үгүй аваас, та мутраа ил гаргаж Сионыг, өөрийн хүмүүст томилсон тэрнийг “гэтэлгээч, Ай Их Эзэн минь.

43a су Бие.

44a су Ач ивээл.

45a су Эцсийн өдрүүд,
Хожмын өдрүүд.

48a су Өрөвч сэтгэл.

49a су Санаатайгаар
алах, Санаатай
аллага.

б Дуул. 13:1–2.

50a су Нигүүлсэнгүй,
Нигүүлсэл.

51a С ба Г 100:13; 105:2.

52 Мөн хэрэв энэ нь өөрөөр байж үл болох аваас, таны хүмүүсийн зорилго таны өмнө бүтэлгүйтэхгүй байхын тулд, мөн таны зэвүүцэл тэдэнд дээр бууж, үндэс хийгээд мөчир аль алинаар нь тэд тэнгэрийн дороос устгагдаж болохын тулд таны уур дүрэлэж болох буюу;

53 Харин тэд наманчлахын хэрээр, нигүүлсэнгүй хийгээд нинжин сэтгэлтэй та Тослогдогчийнхоо нүүрийг хараад хилэгнэлээ зайлуулах болой.

54 Дэлхийн бүх үндэстнүүд дээр нигүүлсэнгүй байгаач, Ай Их Эзэн минь; манай нутгийн захирагчид дээр нигүүлсэнгүй байгаач; хүндэтгэлтэйгээр хийгээд зоримгоор бидний эцгүүдээр хамгаалагдаж ирсэн тэдгээр зарчмууд, нэрлэвэл, манай нутгийн “Үндсэн хууль үүрд үндэслэн байгуулагдах болтугай.

55 Хаад, хунтайж нар, язгууртнууд, мөн дэлхийн агуу ихэс дээдэс, мөн бүх хүмүүс мөн сүмүүд, бүх ядуус, гачигдагсад, мөн дэлхийн зовж зүдрэгсдийг санаач;

56 Таны үйлчлэгчид таны өргөөнөөс гадагш явахад, таны нэрийг гэрчлэхэд тэдний зүрх сэтгэл зөөлрөх болтугай, Ай Иехова; тэдний урьдчилсан сэжиг таавар “үнэний

өмнө зам тавьж өгөхийн тулд, мөн таны хүмүүс бүхний мэлмийд таашаалыг олж болохын тулд буюу;

57 Бид таны үйлчлэгчид таны дуу хоолойг “сонссон, мөн та биднийг илгээсэн гэдгийг дэлхийн бүх хязгаарууд мэдэж болохын тулд буюу.

58 Иаковын хүүхдүүд, таны үйлчлэгчид, тэдэнд таны зарлигласанчлан, таны нэрэнд ариун хотыг барихаар эдгээр бүгдийн дундаас зөв шударгыг үйлдэгчдийг цуглуулж болохын тулд буюу.

59 Таны хүмүүсийн “цугларалт агуу хүч хийгээд сүр жавхланд явагдахын тулд, таны ажил зөв шударга ёсонд түргэссэн байхын тулд, таны томилсон энэ нэгээс гадна бусад гадаснуудыг Сионд томилж өгөхийг бид танаас гуйж байна.

60 “Харийнхантай холбогдсон бидэнд таны өгсөн илчлэлтүүд хийгээд зарлигуудын талаар бид таны өмнө эдгээр үгсийг ярилаа, Ай Их Эзэн минь.

61 Гэвч үүлэрхэг хийгээд харанхуй өдөр урт удаан хугацаагаар уулсаар тараагдсан Иаковын хүүхдүүдийг та агуу ихээр хайрладгаа та мэдэх билээ.

62 Тиймийн тул, “Иерусалим энэ цагаас гэтэлгэгдэж эхлэ-

54a 1 Петр 2:13–15;
С ба Г 98:5–7;
101:77, 80.
су Үндсэн хууль.

56a су Үнэн.

57a С ба Г 20:16;

76:22–24.
59a су Израил—
Израилын
цугларалт.

б Мат. 24:22.

в Иса. 54:2.

60a 1 Ниф. 13:1–32;
15:13–18.

62a 3 Ниф. 20:29.
су Иерусалим.

хийн тулд, Иаковын хүүхдүүд дээр нигүүлсэнгүй байгаач хэмээн бид танаас гуйж байна;

63 Мөн боолчлолын буулга “Давидын удмаас эвдэгдэж хаягдах нь эхэлж болох буюу;

64 Мөн “Иудейн хүүхдүүд, өөрсдийнх нь эцэг Абрахамд таны өгсөн ^бнутгуудад эргэж ирэхийн эхлэл болох буюу.

65 Мөн өөрсдийн зөрчлийн улмаас зүхэгдэж мөн цохигдсон Иаковын “үлдэгдлүүд зэрлэг хийгээд соёл иргэншилгүй байдлаасаа үүрдийн сайн мэдээний бүрэн байдалд ^бхөрвүүлэгдэхэд хүргээч;

66 Тэд цус урсгах зэвсгүүдээ доош тавьж, мөн эсэргүүцлээ зогсоож болохын тулд буюу.

67 Мөн дэлхийн хязгааруудад хөөгдсөн, тараагдсан бүх “Израилын үлдэгдлүүд үнэний мэдлэгт ирж, Мессиад итгэн, мөн дарлалаас гэтэлгэгдэж, мөн таны өмнө баясаж болохын тулд буюу.

68 Өөрийн үйлчлэгч Бага Иосеф Смитийг, мөн түүний бүхий л зовлон зүдгүүрүүд хийгээд мөрдлөг хавчлагуудыг — тэрээр “Иеховатай хэрхэн ^бгэрээнд орж, мөн танд, Ай Иаковын Хүчирхэг Бурханд мэхийн ёсолж байс-

ныг — мөн түүнд таны өгсөн зарлигуудыг, мөн тэрээр таны тааллыг хэрэгжүүлэхийн тулд чин сэтгэлээсээ хичээж байгааг санаач, Ай Их Эзэн минь.

69 Тэд таны оршихуйд өргөмжлөгдөж мөн таны асрамжлагч гараар хамгаалагдахын тулд, түүний эхнэр мөн хүүхдүүдэд нигүүлсэнгүй байгаач, Ай Их Эзэн минь.

70 Тэдний урьдчилсан сэжиг таавар эвдэгдэж мөн үерээр мэт арчигдаж болохын тулд; тэд Израилтай хамт хөрвүүлэгдэн мөн гэтэлгэгдэн мөн та бол Бурхан гэдгийг мэдэхийн тулд тэдний бүх “ойрын садан төрлүүдэд нигүүлсэнгүй байгаач.

71 Баруун гар тань тэднийг, тэдний бүх гэр бүлийн мөн ойрын садан төрлүүдийнх нь хамт өргөмжилж болохын тулд мөн тэдний нэрс үүрд хадгалагдан мөн үеэс үед үүрд санагдаж байхын тулд ерөнхийлөгчдийг, бүр өөрийн сүмийн бүх ерөнхийлөгчдийг санаач, Ай Их Эзэн минь.

72 Гарын оролцоогүйгээр таны бий болгосон “хаант улс агуу уул болж мөн бүхэл дэлхийг дүүргэж болохын

63a су Давид.

64a Зех. 12:6–9;

Мал. 3:4;

С ба Г 133:13, 35.

су Иудей.

^б Эхл. 17:1–8.

су Амалтын нутаг.

65a 2 Ниф. 30:3;

Алма 46:23–24;

3 Ниф. 20:15–21;

С ба Г 19:27.

^б 2 Ниф. 30:6;

3 Ниф. 21:20–22.

су Хөрвүүлэг,

Хөрвөгч.

67a су Израил—

Израилын

цугларалт.

68a су Иехова.

^б су Гэрээ.

70a өх Ойрын төрөл

садан.

72a Дан. 2:44–45;

С ба Г 65:2.

тулд өөрийн бүх сүмийг, тэдний бүх гэр бүл, мөн ойрын садан төрлүүдтэй нь, тэдний бүх өвчтөн хийгээд зовж зүдрэгсэд, мөн дэлхийн бүх ядуус хийгээд номхон дөлгөөнчүүдийг санаач Ай Их Эзэн минь.

73 Таны сүм харанхуйн аглаг буйдаас “сар мэт гэрэлтэн, нар мэт тунгалаг мөн туг хиур бүхий их цэрэг мэт сүртэйеэ өндийн өсч урагш гарч ирэхийн тулд буюу;

74 Мөн та тэнгэрийг нээх тэр өдөр хуримын бэр лугаа адил гоёж, мөн уулс таны оршихуйд доош “тулсахаар мөн ^бхөндийнүүд өргөгдөж, бартаат газрууд тэгш болгогдон, таны алдар суу дэлхийг дүүргэхээр болгооч;

75 Нас барагсдын тул бүрээ дуугарахад, бид Их Эзэнтэй үүрд хамт байж болохын тулд бид таныг угтахаар үүлэн дунд дээш “аваачигдах болно;

76 Бидний өмсгөлүүд цэвэр байж болохын тулд бид зөв шударга ёсны “орхимжуудаар хувцаслагдаж болохын тулд гартаа далдуу модны найлзууртайгаар, мөн тэргүүн дээрээ алдар суугийн ^бтитэмтэйгээр мөн бидний бүхий л ^взовлон зүдгүүрийн хариуд мөнхийн ^ббаяр баяслыг хураахын тулд буюу.

77 Ай Бүхнийг Чадагч Бурхан Их Эзэн минь, биднийг гуйлтуудад маань сонсооч, мөн тэнгэрээс, өөрийн ариун амьдрахуйгаас, хаан сэнтийдээ залран суудаг тэндээс “алдар суу, хүндэтгэл, хүч, сүр жавхлан, хүч чадал, эзэгнэл, үнэн, шударга ёс, шүүлт, нигүүлсэл хийгээд бүрэн байдлын хязгааргүй чанараар, үүрдээс үүрдэд бидэнд хариулаач.

78 Ай сонсооч, Ай сонсооч, Ай биднийг сонсооч, Ай Их Эзэн минь! Эдгээр гуйлтуудад хариулаач, мөн таны нэрэнд бидний барьсан, бидний гарын бүтээл энэ өргөөг танд онцгойлон адислаж байгааг соёрхон хүлээж аваач;

79 Мөн тэрчлэн энэ сүм дээр нэрээ хайрлан соёрхон уу. Мөн Бурханд болон “Хурганд магтаалын мэндчилгээ хүргэн Хосаннаг дуулагч таны хаан сэнтийний эргэн тойрон дахь тэдгээр гэрэлтэгч гялалзсан ^бсерафуудтай бид дуу хоолойгоо нийлүүлж болохын тулд Сүнснийхээ хүчээр бидэнд туслаач!

80 Мөн таны эдгээр тослогдогчид, авралаар “хувцаслагдаг, мөн таны гэгээнтнүүд баяслын улмаас чангаар хашгираг. Амен, мөн Амен.

73a Дуу. 6:10;
С ба Г 5:14; 105:31.
74a С ба Г 133:21–22, 40.
б Иса. 40:4; Лук 3:5;
С ба Г 49:23.
75a 1 Тес. 4:17.

76a Илч. 7:13–15;
2 Ниф. 9:14.
б су Титэм;
Өргөмжлөл.
в Евр. 12:1–11;
С ба Г 58:4.

г су Баяр баясгалан.
77a су Алдар суу.
79a су Бурханы Хурга.
б Иса. 6:1–2.
80a Дуул. 132:16.

ХЭСЭГ 110

1836 оны дөрөвдүгээр сарын 3-нд Огайогийн Көртланд дахь ариун сүмд Бошиглогч Иосеф Смит мөн Оливер Каудерид харуулагдсан үзэгдлүүд оршвой (History of the Church, 2:435–436). Уг үйл явдал нь Хүндэтгэлийн өдрийн цуглааных байлаа. Бошиглогч үзэгдлүүдийн талаарх цэдгийнхээ өмнөх үг болгон: Үдээс хойш энэ өдөр ариун ёслолын ширээний дэргэд ажиллах нь тэдний онцгой боломж байсан Арванхоёроос үүнийг хүлээж аван, Сүмд Их Эзэний Зоогийг түгээхэд нь бусад ерөнхийлөгчдөд би тусалж байлаа. Ах нартаа энэ үйлчлэлийг гүйцэтгэсний дараа, индэрт эргэж ирэхэд хөшиг доош бууж, мөн бибээр Оливер Каудерийн хамт онцгой хүндэтгэлийн хийгээд чимээгүй залбиралд өвдөг сөхрөв. Залбирлаас босч ирсний дараа бид хоёрт дараах үзэгдэл нээгдсэн болой хэмээн эдгээр үгсийг өгүүлжээ. (History of the Church, 2:435).

1–10, Их Эзэн Иехова алдар сууд залран ирж мөн Көртландын Ариун Сүмийг өөрийн өргөө болгон хүлээж авав; 11–12, Мосе мөн Елиас тус бүр залран ирж мөн өөрсдийн түлхүүрүүдийг хийгээд эрин үеүдийг даатгав; 13–16, Елиа эргэж ирэн мөн Малахигаар амлагдсанчлан, өөрийн эрин үеийн түлхүүрүүдийг даатгав.

“ХӨШИГ нь бидний оюунаас авагдаж, мөн бидний ойлголтын ^бмэлмий нээгдсэн байлаа.

2 Индрийн хашлага дээр, бидний өмнө зогсч буй Их Эзэнийг бид харав; мөн түүний хөлөн дор хув шиг өнгөгэй шижир алтаар бүрсэн тавцан байлаа.

3 Түүний “мэлмий галын

дөл лугаа адил байв; тэргүүнийх нь үс цэвэрхэн цас мэт цав цагаан байв; түүний ^бтөрх байдал нарны гэрлээс ч илүү хурцаар гялалзаж байлаа; мөн ^ддуу хоолой нь агуу их ус хуйлрах мэт байв, бүр ^дИеховагийн дуу хоолой өгүүлэн;

4 Бибээр “эхнийх мөн эцсийнх болой; Бибээр ^бамьдардаг тэрээр болой, би бол алагдсан тэрбээр бөлгөө; бибээр Эцэгийн өмнө та нарын ^бөмгөөлөгч билээ.

5 Болгоогтун, нүглүүд чинь “өршөөгдсөн болой та нарт; миний өмнө цэвэр болой та нар; тиймийн тул, тэргүүнээ өргөж мөн баясагтун.

6 Ах дүүсийн чинь зүрх сэтгэл баясаг, мөн өөрсдийн хүчин чадлаар энэ өргөөг миний нэрэнд “барьсан

110 1а су Хөшиг.
б С ба Г 76:12, 19;
136:32; 138:11.
3а Илч. 1:14.
б Илч. 1:16;

ИС—Т 1:17.
в Езек. 43:2; Илч. 1:15;
С ба Г 133:21–22.
г су Иехова.
4а су Ууган.

б Дэд хууль 5:24.
в су Өмгөөлөгч.
5а су Уучлах.
6а С ба Г 109:4–5.

миний бүх хүмүүсийн зүрх сэтгэл баясаг.

7 Учрыг болгоогтун, би энэ “өргөөг” хүлээж авлаа, мөн миний нэр энд байх болно; мөн энэ өргөөнд өөрийн хүмүүст нигүүлсэлд бибээр өөрийгөө үзүүлэх болно.

8 Тийм ээ, хэрэв миний хүмүүс зарлигуудыг минь сахьж, мөн энэ ариун “өргөөг” бохирлохгүй байх аваас, би өөрийн үйлчлэгчдэд “хүрч ирэх болно.

9 Тийм ээ, юүлэгдэх “адислалуудын, мөн энэ өргөөнд миний үйлчлэгчдэд хүртээгдсэн” хишгүүдийн улмаас мянга мянгын мөн хэдэн арван мянгын зүрх сэтгэл агуу ихээр баясах болно.

10 Мөн энэ өргөөний алдар нэр алс холын нутгуудад тархах болно; мөн энэ нь миний хүмүүсийн тэргүүн дээр “юүлэгдэх адислалын эхлэл бөлгөө. Бүр тийм буюу. Амен.

11 Энэ “үзэгдэл хаагдсаны дараа, тэнгэр бидэнд дахин нээгдэв; мөн “Моcе бидний өмнө хүрч ирэн, мөн “умардын нутгаас арван овгийг удирдан мөн дэлхийн дөр-

вөн зүгээс Израилыг “цуглуулах” түлхүүрүүдийг бидэнд даатгав.

12 Үүний дараа “Елиас хүрч ирэн, мөн бид болон бидний дараах бидний бүх үр удам адислагдах болно гэдгийг хэлэн Абрахамын “сайн мэдээний” “эрин үеийг даатгав.

13 Энэ үзэгдэл хаагдсаны дараа, өөр нэгэн агуу хийгээд алдар суут үзэгдэл бидэн дээр гэнэт эхлэв; учир нь үхлийг үзэлгүйгээр тэнгэрт “аваачигдсан бошиглогч” Елиа бидний өмнө зогсч байв, мөн хэлсэн нь:

14 Болгоогтун, Их Эзэний агуу хийгээд аймшигт өдөр ирэхийн өмнө тэр [Елиа] илгээгдэх болно хэмээн нотолж — Малахийн амаар яригдсан тэрхүү цаг бүрнээрээ ирлээ—

15 Бүхэл дэлхий зүхлээр арчигдахгүйн тулд эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүд уруу нь, мөн хүүхдүүдийнхийг эцгүүд уруу нь “эргүүлэх нь буюу.

16 Тиймийн тул, энэ эрин үеийн түлхүүрүүд та нарын гарт даатгагдлаа; мөн үүгээр

7a су Ариун Сүм, Их Эзэний Өргөө.
 б Шаст. дэд 7:16.
 8a су Ариун.
 в С ба Г 97:15–17.
 б С ба Г 50:45.
 9a Эхл. 12:1–3;
 С ба Г 39:15;
 Абр. 2:8–11.
 б С ба Г 95:8.
 су Хишиг
 (индаумент).

10a С ба Г 105:12.
 11a су Үзэгдэл.
 б Мат. 17:3.
 в С ба Г 133:26–32.
 су Израил—Израилын алдагдсан арван овог.
 з Иаков 6:2;
 С ба Г 29:7.
 су Израил—Израилын цугларалт.
 д су Санваарын

түлхүүрүүд.
 12a су Елиас.
 б Гал. 3:6–29.
 су Абрахамын Гэрээ.
 в су Эрин үе.
 13a су Елиа.
 б су Хувирсан биес.
 15a ИС—Т 1:38–39.
 су Удмын бичиг;
 Нас барагсдын аврал.

та нар Их Эзэний агуу хийгээд аймшигт өдөр “ойрхон,

бүр хаалган дээр ирээд байгааг мэдэж болох бөлгөө.

ХЭСЭГ 111

1836 оны наймдугаар сарын 6-нд Масачусетсын Салемд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 2:465-466). Энэ үед Сүмийн удирдагчид тохинуулалд хөдөлмөрлөснийхөө улмаас их өрөнд орсон байлаа. Салемд тэдэнд их хэмжээний мөнгө олдож болохыг сонсоод Бошиглогч, Сидней Ригдон, Хайрум Смит, мөн Оливер Каудери нар Огайогийн Көртландаас, энэ мэдээг судалж үзэхээр сайн мэдээг номлохын сацуу тийшээ очжээ. Ах нар Сүмийн ажил хэргийн хэд хэдэн асуудлаар хэлэлцээр хийж, зарим нэг номлол хийжээ. Мөнгө орж ирэхгүй нь тодорхой болоход тэд Көртланд уруу буцлаа. Уг асуудлаарх нэн чухал хэдэн хүчин зүйл энэхүү илчлэлтийг үгээр илэрхийлэхэд тусгалаа олжээ.

1-5, Их Эзэн өөрийн үйлчлэгчдийн эд материалын хэрэгцээнүүдийг хардаг; 6-11, Тэрээр Сионд нигүүлсэнгүйгээр хандаж мөн өөрийн үйлчлэгчдийн сайн сайхны төлөө бүх зүйлийг зохицуулах болно.

ТА нарын Бурхан Их Эзэн, бибээр та нарыг энэ аяллаар ирсэнд таагүй биш байна, хэдийгээр та нар мунхаглал үйлдсэн ч гэсэн.

2 Та нарын тулд, Сионы ашиг тусын тулд энэ хотод надад их сан хөмрөг буй, мөн Сионы ашиг тусын тулд тогтоосон цагт нь та нарыг зэмсэг болгосноор миний цуглуулах олон хүмүүс энэ хотод буй.

3 Тиймийн тул, та нар удирдагдахынхаа дагуу, мөн энэ нь та нарт өгөгдсөнөөр энэ хот дахь хүмүүстэй

танилцах ёстой нь надад зүйтэй байна.

4 Мөнхүү улиран тохиох дор, тогтоосон цагт би энэ хотыг та нарын гарт өгч, үүн дээр та нар хүчтэй байх болно, ингэхийн хэрээр тэд та нарын нууц хэсгүүдийг илрүүлэхгүй байх болно; мөн алт хийгээд мөнгөнд хамаарах үүний баялаг нь та нарынх байх болно.

5 “Өрийнхөө төлөө өөрсдөө бүү санаа зов, учир нь үүнийг төлөх хүчийг би та нарт өгөх болно.

6 Сионы төлөө өөрсдөө бүү санаа зов, учир нь түүнд би нигүүлсэнгүй хандах болно.

7 Энэ газарт мөн эргэн тойрны бүс нутгуудад үлдэгтүн.

8 Мөн үндсэн зорилгынхоо учир та нар энэ газар үлдэх ёстой нь миний таалал болой, энэ нь та нар уруу

урсах миний Сүнсний “амар амгалан хийгээд хүчээр та нарт дохиологдох болно.

9 Энэ газрыг та нар түрээсээр олж авч болох буюу. Мөн энэ хотын нэн эртний оршин суугчид хийгээд үндэслэгчдийн талаар хичээнгүйлэн асууж сурагла;

10 Учир нь та нарт зориу-

лагдсан нэгээс илүү сан хөмрөг энэ хотод буй.

11 Тиймийн тул та нар наж могой мэт “овжин, тэгэхдээ нүгэлгүй бай; мөн бибээр бүх зүйлийг аль болох түргэнээр та нар тэдгээрийг хүлээн авч чадахаар, та нарын ⁶сайн сайхны төлөө тушаах болно. Амен.

ХЭСЭГ 112

1837 оны долдугаар сарын 23-нд Огайогийн Көртландад Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Томас Б.Маршид өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 2:499–501). Энэхүү илчлэлт Хурганы Арванхоёр Төлөөлөгчийн талаар Томас Б.Маршид өгсөн Их Эзэний үгийг агуулдаг. Сайн мэдээ Англид анх номлогдсон тэр өдөр энэхүү илчлэлт хүлээн авагдсаныг Бошиглогч тэмдэглэсэн байдаг. Энэ үед Томас Б.Марш Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч байв.

1–10, Арванхоёр нь бүх үндэстэн хийгээд хүмүүст сайн мэдээг илгээж мөн сэрэмжлүүлгийн дуу хоолойг өргөх ёстой; 11–15, Тэд загалмайгаа үүрч, Есүсийг даган мөн түүний хонинуудыг тэжээх ёстой; 16–20, Тэргүүн Зөвлөлийг хүлээн авдаг тэд Их Эзэнийг хүлээн авдаг; 21–29, Харанхуй нь дэлхийг бүрхдэг, мөн гагцхүү итгэдэг мөн баптисм хүртдэг тэд аврагдах болно; 30–34, Тэргүүн Зөвлөл хийгээд Арванхоёр нь цаг хугацааны бүрэн байдлын эрин үеийн түлхүүрүүдийг атгадаг.

ҮНЭНЭЭР Их Эзэн өөрийн үйлчлэгч Томас Б.Марш чамд ийн хэлж байна: залбирлуудыг чинь сонслоо би;

мөн миний нэрийг гэрчилж мөн үүнийг бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүст хол “илгээхээр сонгогдон, мөн миний үйлчлэгчдийн зэмсгээр дамжин томилогдсон тэдгээр ах дүүсийн чинь өмнөөс өглөгүүд чинь миний өмнө ⁶дурсамж болон ирлээ.

2 Үнэнээр би чамд хэлж байна, Их Эзэн миний таалалд чи эс нийцэх зарим цөөн зүйл зүрх сэтгэлд чинь болон чамд бий болсон байна.

3 Гэсэн хэдий ч, чи өөрийгөө “дорд аваачихын хэрээр чи өргөмжлөгдөх болно, тиймийн тул, бүх нүгэл чинь өршөөгдсөн болой чамд.

4 Зүрх сэтгэл чинь миний

8а С ба Г 27:16.
су Амар амгалан.
11а Мат. 10:16.

б Ром 8:28;
С ба Г 90:24; 100:15.
112 1а С ба Г 18:28.

б Үйлс 10:4.
3а Мат. 23:12;
Лук 14:11.

нүүрний өмнө “хөхүүн баярт байг; мөн чи миний нэрийг зөвхөн ^бхарийнханд төдийгүй, мөн ^виудейчүүдэд гэрчлэх ёстой; мөн чи миний үгйг дэлхийн хязгааруудад урагш илгээх ёстой.

5 Тиймийн тул, чи өглөөнөөс өглөөг дараалан “тэмц; мөн өдөр өдрөөр ^бсэрэмжлүүлгийн дуу хоолой чинь урагш одог; мөн шөнө байхад чиний ярианы улмаас, дэлхийн оршин суугчид бүү нойрсог.

6 Сионд чиний оршин суух газар мэдэгдэг, мөн гэр орноо бүү “шилжүүл; учир нь хүмүүний үрсийн дунд миний нэрийг түгээлгэн чамаар хийлгэх ажил Их Эзэн надад буй.

7 Тиймийн тул, уг ажлын тул “бүсээ бүслэгтүн. Хөлд чинь гутал өмсөгдөг, учир нь сонгогдсон болой чи, мөн зөрөг чинь уулсын дунд мөн олон үндэстний дунд буй.

8 Мөн чиний үгээр олон ихэс дээдэс “дорд аваачигдах болно, мөн чиний үгээр олон сул доройчууд өргөмжлөгдөх болно.

9 Дуу хоолой чинь зөрчил гаргагчид зэмлэл байх болно; мөн гүтгэгчийн хэл чиний зэмлэлд мушгин гуйвуулахаа болиг.

10 Чи “даруу бай; тэгвэл чиний Бурхан Их Эзэн чамайг гараас чинь хөтөлж мөн залбирлуудад чинь чамд хариу өгөх болно.

11 Зүрх сэтгэлийг чинь би мэднэ, ах дүүсийн чинь талаарх залбирлуудыг чинь сонссон билээ. Тэднийг хайрлах “хайр чинь бусад олноос дээгүүрт, ялгавартай бүү байг, харин тэднийг хайрлах хайр чинь өөрийгөө хайрлахын адил байг; мөн бүх хүмүүнд, мөн миний нэрийг хайрладаг тэд бүгдэд хайр чинь элбэг дэлбэг байг.

12 Мөн Арванхоёрын ах нарынхаа төлөө залбирагтун. Миний нэрийн тулд тэднийг хурцаар сануулагтун, мөн тэд бүхий л нүглүүдийнхээ улмаас сануулагдаг, мөн та нар миний “нэрэнд миний өмнө итгэлтэй байгтун.

13 Мөн тэдний “уруу таталтууд, мөн их ^бгай зовлонгийн дараа, болгоогтун, Их Эзэн бибээр тэднийг бодох болно, мөн хэрэв тэд зүрх сэтгэлээ үл хатууруулах аваас, мөн миний эсрэг хүзүүгээ хөшүүн болгохгүй аваас, тэд “хөрвүүлэгдэх болно, мөн бибээр тэднийг эдгээх болно.

14 Эдүгээ, би чамд хэлье, мөн би чамд хэлснээ, би бүх

4a Мат. 9:2;

Иохан 16:33.

б С ба Г 18:6; 90:8–9.

в С ба Г 19:27.

5a Иудей 1:3.

б С ба Г 1:4–5.

6a Дуул. 125:1.

7a Ефес 6:13–17.

8a су Даруу, Даруу

байдал.

10a Сур. үгс 18:12.

11a Мат. 5:43–48.

су Энэрэл; Хайр.

12a су Есүс Христ—

Өөрсөд дээрээ

Есүс Христийн

нэрийг авах.

13a су Уруу татах,

Уруу таталт.

б Иохан 16:33;

Илч. 7:13–14;

С ба Г 58:3–4.

в 3 Ниф. 18:32.

су Хөрвүүлэг,

Хөрвөгч.

Арванхоёрт хэлнэм: Босогтун мөн бүсээ бүсэлж, “загалмайгаа үүрч, намайг даган хонинуудыг минь ^бтэжээгтүн.

15 Өөрсдийгөө бүү өргөмжил; миний үйлчлэгч Иосефын эсрэг бүү “бос; учир нь үнэнээр би чамд хэлж байна, би түүнтэй хамт байна, мөн миний гар түүн дээр байх болно; мөн түүнд мөн тэрчлэн та нарт миний өгсөн ^бтүлхүүрүүд намайг ирэх хүртэл түүнээс авагдах нь үгүй.

16 Үнэнээр би чамд хэлж байна, миний үйлчлэгч Томас, чи бол миний хаант улсын түлхүүрүүдийг, Арванхоёрт хамаарахын хувьд, алс холд бүх үндэстнүүдийн дунд атгахаар миний сонгож авсан тэр хүн бөлгөө —

17 Миний үйлчлэгч Иосеф, мөн миний үйлчлэгч “Сидней, мөн миний үйлчлэгч ^бХайрум нар очиж чадахгүй бүх газарт чи хаант улсын хаалгыг нээх миний үйлчлэгч байж болохын тулд буюу;

18 Учир нь бүх сүмийн ачааг би багахан хугацаагаар тэдэн дээр үүрүүлсэн билээ.

19 Иймийн тул, тэд чамайг хааш нь ч илгээлээ гэсэн, чи явагтун, мөн би чамтай хамт байх болно; мөн ямар ч газарт чи миний нэрийг тунхагла-

лаа гэсэн, тэд миний үгийг хүлээн авч болохын тулд “үр дүнтэй хаалга чамд нээгдэх болно.

20 Миний үгийг “хүлээн авдаг хэн боловч, намайг хүлээн авдаг, мөн намайг хүлээн авдаг хэн боловч миний илгээсэн тэднийг миний нэрийн тулд чамд бибээр зөвлөхүүд болгосон, Тэргүүн Зөвлөлийг хүлээн авдаг болой.

21 Мөн дахин би чамд хэлнэ, миний нэрээр чи хэнийг ч илгээлээ гэсэн, тэд ах дүүсийн чинь, “Арванхоёрын дуу хоолойгоор зохих ёсоор зарлигдуулж мөн чамаар зөвшөөрөгдөж мөн ^бэрх мэдэлтэй болгогдож, тэднийг чи тийш нь илгээсэн аль ч үндэстэнд миний хаант улсын хаалгыг нээх хүчтэй байх болно —

22 Тэд миний өмнө өөрсдийгөө даруусгаж мөн миний үгэнд оршиж мөн миний Сүнсний дуу хоолойг “сонсохын хэрээр буюу.

23 Үнэнээр, үнэнээр би чамд хэлж байна, “харанхуй нь дэлхийг, мөн түнэр харанхуй нь хүмүүсийн оюуныг бүрхэж, мөн бүх махан бодь миний нүүрний өмнө ^бялзарчээ.

24 Болгоогтун, хилэгнэлийн өдөр, шатаалтын өдөр, эз-

14a Мат. 16:24. исо, Мат. 16:25–26; Лук 9:23.

б Иохан 21:15–17.

15a су Эсэргүүцэл.

б С ба Г 28:7.

су Санваарын

түлхүүрүүд.

17a су Сидней Ригдон.

б су Смит Хайрум.

19a 1 Кор. 16:9;

С ба Г 118:3.

20a С ба Г 84:35–38.

21a С ба Г 107:34–35.

б су Эрх мэдэл.

22a су Сонсох;

Дуулгавартай

байдал, Дуулгавар-

тай, Дуулгавартай дагах.

23a Иса. 60:2;

Мика 3:6;

С ба Г 38:11.

су Урвалт—

Эртний Христийн

Сүмийн урвалт.

б С ба Г 10:20–23.

гүйрлийн, “уйлааны, гашуудлын мөн уй гашуугийн өдөр”^б өс хонзон дэлхийн оршин суугчид дээр даруй тохиох ажгуу; мөн энэ нь хуй салхи лугаа адил дэлхийн бүх гадаргуу дээр ирэх болно хэмээн Их Эзэн хэлж байна.

25 Мөн энэ нь миний өргөөн дээр “эхэлж, мөн миний өргөөнөөс урагш одох болно хэмээн Их Эзэн хэлж байна.

26 Эхлээд, миний нэрийг мэддэг “дүр эсгэдэг атлаа намайг”^б мэддэггүй, мөн миний өргөөн дотор миний эсрэг “гутаан доромжилсон та нарын дундах тэдний дунд буюу хэмээн Их Эзэн хэлж байна.

27 Тиймийн тул, энэ газар дахь миний сүмийн хэрэг явдлуудын талаар та нар өөрсдөө тэвдэн сандрахгүйн тулд үүнийг мэдэгтүн хэмээн Их Эзэн хэлж байна.

28 Харин миний өмнө зүрх сэтгэлээ “ариусгагтун; мөн тэгээд бүх дэлхий уруу”^б явагтун та нар, мөн үүнийг хүлээн аваагүй байгаа хүн бүхэнд миний сайн мэдээг номлогтун;

29 Мөн “итгэдэг хийгээд”^б баптисм хүртдэг тэрээр

аврагдах болно, мөн итгэдэггүй, мөн баптисм хүртдэггүй тэрээр “яллагдах болно.

30 Учир нь та нарт, “Арванхоёрт, мөн та нарын зөвлөхүүд хийгээд удирдагчид байхаар та нарын хамт томилогдсон”^б Тэргүүн Зөвлөлд, эцсийн өдрүүдийн төлөө мөн эцсийн удаад, цаг хугацааны бүрэн байдлын “эрин үед энэхүү санваарын хүч өгөгдсөн болой.

31 Уг хүчийг та нар бүтээлтийн эхлэлээс хойших ямар ч цагт, эрин үеийг хүлээж авсан тэд бүгдтэй хамт атгаж байгаа билээ;

32 Учир нь үнэнээр би та нарт хэлж байна, та нарын хүлээн авсан эрин үеийн “түлхүүрүүд, эцгүүдээс доош”^б бууж ирсэн мөн бүхнээс сүүлд та нарт тэнгэрээс доош илгээгдсэн билээ.

33 Үнэнээр би та нарт хэлж байна, дуудлага тань хичнээн агууг болгоогтун. Энэ үеийнхний цус та нарын гараас “шаардагдахгүйн тулд зүрх сэтгэлээ мөн өмсгөлүүдээ”^б цэвэршүүлэгтүн.

34 Намайг ирэх хүртэл итгэлтэй бай, учир нь би гэнэт “ирнэ; мөн хүн болгонд”^б аж-

24a С ба Г 124:8.

б су Өс хонзон.

25a 1 Петр 4:17–18.

26a Мат. 7:21–23;

С ба Г 41:1; 56:1.

б Лук 6:46;

Мозая 26:24–27;

3 Ниф. 14:21–23.

в су Доромжлох,
Доромжлол.

28a су Цэвэр ариун,
Цэвэр ариун

байдал.

б Марк 16:15–16.

29a Морм. 9:22–23;

С ба Г 20:25–26.

б су Баптисм,
Баптисм хүртээх.

в су Ял.

30a су Төлөөлөгч.

б су Тэргүүн Зөвлөл.

в Ефес 1:10;

С ба Г 27:13;

124:40–42.

су Эрин үе.

32a С ба Г 110:11–16.

су Санваарын

түлхүүрүүд.

б Абр. 1:2–3.

33a С ба Г 72:3.

б Иаков 1:19.

34a Илч. 22:7, 12;

С ба Г 49:28; 54:10.

б су Ажлууд.

лынх нь дагуу төлөхийн тулд миний шагнал надтай хамт

байх болно. Би бол Альфа ба Омега. Амен.

ХЭСЭГ 113

1838 оны гуравдугаар сард Исаиагийн бичээсүүдийн талаарх зарим асуултад Бошиглогч Иосеф Смитээр өгөгдсөн хариултауд оршвой (History of the Church, 3:9–10).

1–6, Иессийн гол иш, түүнээс урган гарах мөчир, мөн Иессийн үндэс тогтоогдов; 7–10, Сионы тараагдсан үлдэгсэд санваарт эрхтэй бөгөөд Их Эзэнд эргэж ирэхээр дуудагдав.

ИСАИАГИЙН 11-р бүлгийн 1-р, 2-р, 3-р, 4-р, мөн 5-р шүлгүүдэд өгүүлэгддэг “Иессийн Гол Иш хэн бэ?

2 Үнэнээр Их Эзэн ийн хэлдэг: Энэ бол Христ бөлгөө.

3 Исаиагийн 11-р бүлгийн нэгдүгээр шүлэгт өгүүлэгддэг Иессийн гол ишнээс ирэх ёстой тэр мөчир юу вэ?

4 Болгоогтун, ийн Их Эзэн хэлдэг: Энэ бол Христийн гар дахь Иессийн, мөн түүнчлэн “Ефраимын, эсвээс Иосефын угсааны хагас удам болох, дээр нь их ^бхүч тавигдсан нэг үйлчлэгч бөлгөө.

5 11-р бүлгийн 10-р шүлэгт өгүүлэгддэг Иессийн үндэс юу вэ?

6 Болгоогтун, ийн Их Эзэн хэлдэг: Энэ бол Иессийн мөн түүнчлэн Иосефын удам билээ, мөн “тугны тулд, мөн

эцсийн өдрүүдэд миний хүмүүсийн ^бцугларалтын тулд санваар болон хаант улсын ^бтүлхүүрүүд түүнд зүй ёсоор харьяалагддаг буюу.

7 Елиас Хигбеегийн асуултауд: Исаиад, 52-р бүлэг, нэгдүгээр шүлэгт: Хүчин чадлаа өмсөгтүн Ай Сион—хэмээх зарлиг ямар учиртай вэ? Мөн Исаиа ямар хүмүүсийг дурдсан бэ?

8 Эцсийн өдрүүдэд Бурхан дуудах учиртай тэднийг, “Сионыг дахин мөн Израилын гэтэлгэлийг авчрах санваарын хүчийг атгах ёстой тэднийг тэрээр дурджээ; мөн хүчин чадлаа тэр өмсөгтүн гэдэг нь тэр, Сион удам угсаагаараа ^бэрхтэй байдаг санваарын эрх мэдлийг өмсөнө гэсэн үг юм; тэрчлэн тэрээр алдсан ^бхүчиндээ эргэж ирэх болно.

9 2-р шүлэгт: Хүзүүнийхээ хүлээснээс өөрийгөө суллаж буй Сионоор бид юуг ойлгох ёстой вэ?

10 “Тараагдсан үлдэгсэд унасан байдлаасаа Их Эзэнд

113 1a су Иесс.
4a Эхл. 41:50–52;
С ба Г 133:30–34.
су Ефраим.
б су Хүч.
6a С ба Г 45:9.

су Туг.
б су Израил—
Израилын
цугларалт.
в су Санваарын
түлхүүрүүд.

8a су Сион.
б су Өвлөх эрх.
в С ба Г 82:14.
10a су Израил—
Израилын
тараагдалт.

^бэргэж ирэхээр ухуулагдана хэмээн бид ойлгох ёстой; хэрэв тэд үүнийг хийх аваас, Их Эзэний амлалт бол тэрээр тэдэнд ярих буюу тэдэнд илчлэлт өгөх нь болой. 6, 7,

8-р шүлгүүдийг үз. Түүний хүзүүний хүлээс нь түүн дээрх Бурханы зүхэл буюу Израилын үлдэгдлүүд харийнханы дунд тараагдсан байдал болой.

ХЭСЭГ 114

1838 оны дөрөвдүгээр сарын 17-нд Миссурийн Фар Вестэд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 3:23).

1–2, *Итгэлтэй бус тэдний хаашдаг Сүмийн албан тушаалууд бусдад өгөгдөх болно.*

ҮНЭНЭЭР ийн Их Эзэн хэлж байна: Ирэх хавар бусадтай хамтран, бүр өөрийг нь оролцуулан арванхоёртой хамт үүрэг даалгаврыг гүйцэтгэж, бүх дэлхийд миний нэрийг гэрчилж мөн баярт мэдээг хүргэхийн тулд тэрээр өөрийн бүх ажил

хэргийг чадахынхаа хэрээр аль болох түргэн шийдвэрлэж, арилжаа наймааныхаа ажлаас салах нь миний үйлчлэгч Давид В.Паттенд орших мэргэн ухаан болой.

2 Учир нь үнэнээр ийн Их Эзэн хэлэв, миний нэрийг үгүйсгэдэг тэд та нарын дунд байхын хэрээр тэдний “оронд бусад нь ^бтавигдаж мөн тэднийг бишопын зөвлөлдөө хүлээн авах болно. Амен.

ХЭСЭГ 115

1838 оны дөрөвдүгээр сарын 26-нд Миссурийн Фар Вестэд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн уг газрын тухай болон Их Эзэний өргөө барих талаарх Бурханы тааллыг мэдэгдсэн илчлэлт оршвой (History of the Church, 3:23–25). Энэхүү илчлэлт Сүмийн тэргүүлэх ажилтнуудад ханджээ.

1–4, *Их Эзэн өөрийн сүмийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм хэмээн нэрлэв; 5–6, Сион болон түүний гадаснууд Гэгээнтнүүдийн хувьд хамгаалалтын хийгээд хоргодох газрууд болой; 7–16, Гэгээнтнүүд Фар Вестэд Их Эзэний*

өргөө барихаар зарлигдуулав; 17–19, Иосеф Смит дэлхий дээрх Бурханы хаант улсын түлхүүрүүдийг атгадаг.

ҮНЭНЭЭР ийн Их Эзэн өөрийн үйлчлэгч Бага “Иосеф Смит чамд, мөн тэрч-

лэн өөрийн үйлчлэгч ^бСидней Ригдон, мөн тэрчлэн өөрийн үйлчлэгч ^вХайрум Смит, мөн одоо байгаа болон үүнээс хойш томилогдох та нарын зөвлөхүүдэд хэлж байна;

2 Мөн тэрчлэн миний үйлчлэгч ^аЭдвард Партриж чамд, мөн чиний зөвлөхүүдэд буюу;

3 Мөн тэрчлэн Сион дахь миний сүмийн дээд зөвлөлийнх болох миний итгэлтэй үйлчлэгчдэд буюу, учир нь энэ нь ийн нэрлэгдэх ёстой, мөн бүх дэлхий даяар алс холд тараагдсан Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн миний сүмийн бүх ахлагч болон хүмүүст буюу;

4 Учир нь эцсийн өдрүүдэд миний ^асүм ийн, бүр ^бЕсүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм хэмээн нэрлэгдэх ёстой.

5 Үнэнээр би та бүгдэд хэлж байна: Та нарын гэрэл үндэстнүүдийн хувьд ^ажишиг байж болохын тулд ^ббосч мөн урагш гэрэлтүүл;

6 Мөн ^аСионы газар нутагт, мөн түүний ^бгадаснуудад ^вхамтдаа цуглах нь батлан хамгаалалтын тулд, мөн шуурганаас, мөн энэ нь хольцгүйгээр бүхэл дэлхий дээр ^гюүлэгдэх үед хилэгнэ-

лээс ^дхоргодох газар байж болохын тулд буюу.

7 Фар Вест хот, миний хувьд ариун хийгээд ариулан адислагдсан газар байг; мөн энэ нь хамгийн ариун хэмээн нэрлэгдэх болно, учир нь дээр нь чиний зогсож буй газар бол ^аариун бөлгөө.

8 Гиймийн тул, миний гэгээнтнүүд хамтдаа цуглаж, тэд намайг ^ашүтэн биширч болохын тулд, надад өргөө ^ббарихыг би та нарт зарлиглаж байна.

9 Мөн энэ ажлын эхлэл мөн суурь мөн бэлтгэл ажил нь энэ дараагийн зун байг;

10 Мөн эхлэл нь ирэх долдугаар сарын дөрөв дэх өдөр хийгдэг; мөн тэр цагаас хойш миний хүмүүс миний нэрэнд өргөө барихаар хичээнгүйлэн хөдөлмөрлөг;

11 Мөн энэ өдрөөс хойш ^анэг жилийн дараа тэд миний ^бөргөөний суурийг дахин эхлэг.

12 Ийн тэд тэр цагаас хойш энэ нь үүний тулгуурын чулуунаас оройг нь хүртэл дуусаагүй юм юу ч үлдэхгүй байх хүртэл дууссан байхаар хичээнгүйлэн хөдөлмөрлөг.

13 Үнэнээр би та нарт хэлж байна, миний үйлчлэгч Иосеф ч, мөн миний үйлчлэгч Сидней ч, мөн миний

1б су Сидней Ригдон.
в су Смит Хайрум.

2а су Эдвард
Партриж.

4а 3 Ниф. 27:4–8.

б су Есүс Христийн
Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн
Сүм.

5а Иса. 11:12.
су Туг.

б Иса. 60:1–3.
6а су Сион.

б С ба Г 101:21.
су Гадас.

в су Израил—
Израилын
цугларалт.

г Илч. 14:10;
С ба Г 1:13–14.

д Иса. 25:1, 4;
С ба Г 45:66–71.

7а су Ариун.

8а су Шүтэн бишрэх.
б С ба Г 88:119; 95:8.

11а С ба Г 118:5.
б С ба Г 124:45–54.

үйлчлэгч Хайрум ч, миний нэрэнд өргөө барихын тулд дахиад өрөнд бүү орог;

14 Харин тэдэнд миний үзүүлэх тэр “загварын дагуу миний нэрэнд өргөө баригдаг.

15 Мөн хэрэв миний хүмүүс, тэдний ерөнхийлөгчийн зөвлөлд миний үзүүлэх загварын дагуу барихгүй аваас, би үүнийг тэдний гараас хүлээж авах нь үгүй.

16 Харин хэрэв миний хүмүүс тэдний ерөнхийлөгчийн зөвлөлд бүр миний үйлчлэгч Иосеф болон түүний зөвлөхүүдэд миний үзүүлэх загварын дагуу үүнийг барих аваас, тэгвэл би үүнийг өөрийн хүмүүсийн гараас хүлээж авах болно.

17 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, Фар Вестийн хот миний гэгээнтнүүдийн цугларалтаар үтэр түргэн баригдах ёстой нь миний таалал билээ;

18 Мөн тэрчлэн тэдгээр нь миний үйлчлэгч Иосеф Смитэд цагаас цагт үзүүлэгдэхийн дагуу “гадаснуудад зориулсан бусад газрууд эргэн тойрны бүс нутгуудад тогтоогдох ёстой нь буюу.

19 Учрыг болгоогтун, би түүнтэй хамт байх болно, мөн би түүнийг хүмүүсийн өмнө ариусгах болно; учир нь энэ хаант улс хийгээд тохинууллын “түлхүүрүүдийг би түүнд өгсөн билээ. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 116

1838 оны тавдугаар сарын 19-нд Миссурийн Давиесс гүнлэгийн Спринг Хилл хэмээх газарт, Вайтын Феррийн ойролцоо Бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оршой (History of the Church, 3:35).

СПРИНГ Хиллийг “Адам-ондай-Аман хэмээн Их Эзэн нэрлэв, учир нь энэ нь “Адам өөрийн хүмүүст,

эсвээс бошиглогч Даниелаар өгүүлэгдсэнчлэн, “Эртний Одрүүд суухаар ирэх тэр газар болой хэмээн тэрээр хэлэв.

ХЭСЭГ 117

1838 оны долдугаар сарын 8-нд Миссурийн Фар Вестэд Виллям Маркс, Ньюел К.Витней, мөн Оливер Гранжер нарын хойшлуулишгүй үүргүүдийн талаар Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршой (History of the Church, 3:45–46).

14а Евр. 8:5;
С ба Г 97:10.
18а С ба Г 101:21.
су Гадас.

19а су Санваарын
түлхүүрүүд.
116 1а С ба Г 78:15.
су Адам-ондай-

Аман.
б су Адам.
в Дан. 7:13–14, 22.

1–9, *Их Эзэний үйлчлэгчид эд материалын зүйлүүдэд шунах ёсгүй, учир нь “Их Эзэнд өмч хөрөнгө юуны хамаа байна?”*; 10–16, *Тэд бодгалийн өчүүхэн чанарыг орхих ёстой, мөн тэдний золиослолууд Их Эзэнд ариун нандин байх болно.*

ҮНЭНЭЭР ийн Их Эзэн өөрийн үйлчлэгч Виллям Маркс, мөн тэрчлэн өөрийн үйлчлэгч Ньюел К.Витнейд хэлж байна, тэд өөрсдийн ажлыг үтэр түргэн шийдэж мөн Их Эзэн намайг дэлхийд цасыг дахин илгээхээс өмнө Көртландын нутгаас яваг.

2 Тэд сэрэг, мөн босог, мөн урагш ирэг, мөн бүү үлдэг, учир нь Их Эзэн бибээр үүнийг зарлиглаж байна.

3 Тиймийн тул, хэрэв тэд үлдэх аваас тэдэнд сайн биш байх болно.

4 Тэд бүх нүглээсээ мөн бүх шунаг хүслүүдээсээ миний өмнө наманчлаг хэмээн Их Эзэн хэлж байна; учир нь надад “өмч хөрөнгө юуны хамаа байна? хэмээн Их Эзэн хэлэв.

5 Көртландын өмч хөрөнгө “өрийн улмаас борлуулагдаг хэмээн Их Эзэн хэлж байна. Тэдгээр нь зарцуулагдаг хэмээн Их Эзэн хэлж байна, мөн юу ч үлдлээ гэсэн, энэ нь та нарын гарт байг хэмээн Их Эзэн хэлж байна.

6 Учир нь агаарын жигүүртнүүд, мөн тэрчлэн тэнгис далайн загас, мөн уулын амьтад надад үгүй гэж үү? Би дэлхийг бий болгоогүй гэж үү? Дэлхийн үндэстнүүдийн бүх их цэргийн “хувь заяаг би атгадаггүй гэж үү?

7 Тиймийн тул бибээр “эзлүүд газруудыг нахиалахаар хийгээд цэцэглэхээр болгохгүй, мөн элбэг дэлбэгт урагш авчрахгүй гэж үү? хэмээн Их Эзэн хэлдэг.

8 “Адам-ондай-Аманы уулс дээр, мөн Олаха “Шинехагийн талууд дээр, эсвээс Адамын оршин суудаг асан “газар дээр хангалттай зай буй атал та нар жижигхэн тэр зүйлд шунаж мөн илүү жинтэй асуудлуудыг үл хайхрах ёстой гэж үү?

9 Тиймийн тул, ийшээ миний хүмүүсийн, бүр Сионы нутагт ирэгтүн.

10 Миний үйлчлэгч Виллям Маркс цааш хэдэн зүйл дээр “итгэлтэй байг, мөн тэрээр олон зүйлийн захирагч байх болно. Тэрээр Фар Вестийн хот дахь миний хүмүүсийн дунд тэргүүлэг, мөн тэрээр миний хүмүүсийн адислалуудаар адислагдаг.

11 Миний үйлчлэгч Ньюел К.Витней “николайчуудын бүлэглэлээс, мөн тэдний бүхий л ^бнууц жигшүүрт хэргүүдээс, түүнчлэн миний

117 4a С ба Г 104:14.

5a С ба Г 104:78.

6a Үйлс 17:26;

1 Ниф. 17:36–39.

7a Иса. 35:1;

С ба Г 49:24–25.

8a С ба Г 116:1.

су Адам-ондай-

Аман.

б Абр. 3:13.

в су Еден.

10a Мат. 25:23.

11a Илч. 2:6, 15.

б су Нууц

хуйвалдаанууд.

өмнө өөрийн бодгалийн өчүүхэн чанараас ичиг, хэмээн Их Эзэн хэлнэ, мөн Адам-ондай-Аманы нутагт өгсөн очиж, мөн миний хүмүүст нэрийн төдий бус, харин үйлсээрээ “бишоп байг хэмээн Их Эзэн хэлж байна.

12 Мөн дахин, би та нарт хэлж байна, би өөрийн үйлчлэгч “Оливер Гранжерыг дурсан санаж байна; болгоогтун, түүний нэр үеэс үед хийгээд үүрд мөнхөд ариун нандин дурсамжид байх болно хэмээн би үнэнээр түүнд хэлж байна.

13 Тиймийн тул, тэрээр миний Сүмийн Тэргүүн Зөвлөлийн гэтэлгэлийн төлөө тэмцэг хэмээн Их Эзэн хэлж байна; мөн тэрээр унаад, тэрээр дахин босч ирэх болно, учир нь түүний өсөлтөөс илүүгээр түүний “золиослол надад илүү ариун нандин байх болно хэмээн Их Эзэн хэлж байна.

14 Тиймийн тул, тэр тийшээ Сионы нутагт үтэр түргэн очиг; мөн тогтоосон цаг нь болоход тэрээр миний хүмүүсийн ашиг тусын тулд миний нэрэнд наймаачин болгогдох болно хэмээн Их Эзэн хэлж байна.

15 Тиймийн тул, миний үйлчлэгч Оливер Гранжерийг хүмүүн бүү үл тоомсорлог, харин миний хүмүүсийн адислалууд түүн дээр үүрд мөн мөнхөд байг.

16 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, мөнгө хүүлэгчдийг би өөрийнхөө тогтоосон цагт таягдан хаяхын тулд мөн миний өргөөг ариунаар хадгалж мөн хамгаалахын тулд Кертландын нутаг дахь миний бүх үйлчлэгчид Бурхан Их Эзэнээ тэрчлэн үүнийг дурсан санаг хэмээн Их Эзэн хэлж байна. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 118

1838 оны долдугаар сарын 8-нд Миссурийн Фар Вестэд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан, “Ай Их Эзэн минь, Арванхоёрын талаарх өөрийн тааллыг бидэнд үзүүлээч” хэмээсэн даруухан залбирлын хариуд өгөгдсөн илчлэлт оривой (History of the Church, 3:46).

1–3, Арванхоёрын гэр бүлүүдийг Их Эзэн хангах болно; 4–6, Арванхоёр дахь сул орон тоонууд бөглөгдөв.

ҮНЭНЭЭР ийн Их Эзэн хэлж байна: Чуулган нэн даруй болог; Арванхоёр зохион байгуулагдаг; мөн

11в су Бишоп.
12а өх Энэ хэргийг
зохицуулахаар

Иосеф Смитийн
Кертландад үлдээ-
сэн төлөөний хүн.

13а су Золиослол.

унасан тэдний “ормыг нөхөхөөр эрчүүд томилогдог.

2 Миний үйлчлэгч “Томас миний үгийг нийтлэхийн тулд Сионы нутагт багахан хугацаагаар үлдэг.

3 Үлдэгсэд нь тэр цагаас эхлэн номлохоо үргэлжлүүлэг, мөн хэрэв тэд үүнийг зүрх сэтгэлийн бүхий л номхон дөлгөөнд хийгээд “даруу байдалд мөн ⁶тэвчээрт хийх аваас, тэдний гэр бүлүүдийг би хангах болно хэмээх амлалтыг Их Эзэн бибээр тэдэнд өгч байна; мөн үүнээс хойш үр дүнтэй хаалга тэдний төлөө нээгдэх болно.

4 Мөн ирэх хавар тэд агуу их усан дээгүүр алс одог, мөн тэнд миний сайн мэдээг,

үүний бүрэн байдлыг дэлгэрүүлж, мөн миний нэрийг гэрчлэг.

5 Дөрөвдүгээр сарын хорин зургаа дахь өдөр миний өргөөг барих газар уруу Фар Вестийн хот дахь миний гэгээнтнүүдээс тэд салж яваг хэмээн Их Эзэн өгүүлж байна.

6 Миний үйлчлэгч Жон Тейлор мөн тэрчлэн миний үйлчлэгч Жон Е.Пейж, бас тэрчлэн миний үйлчлэгч Вилфорд Вудрафф, мөн тэрчлэн миний үйлчлэгч Виллард Ричардс, унасан тэдний орыг бөглөхөөр томилогдог, мөн тэдний томилолтын тухай албан ёсоор мэдэгдэг.

ХЭСЭГ 119

1838 оны долдугаар сарын 8-нд Миссурийн Фар Вестэд, “Ай Их Эзэн минь Аравны нэгийн тул та өөрийн хүмүүсийн өмч хөрөнгөнөөс хичнээнийг шаардахыг өөрийн үйлчлэгчид үзүүлнэ үү” хэмээсэн түүний даруухан залбирлын хариуд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оривой (History of the Church, 3:44). Өнөөдөр ойлгодгоор, аравны нэгийн хууль нь энэ илчлэлтээс өмнө Сүмд өгөгдөөгүй байсан ажээ. Аравны нэг гэдэг нэр томьёо нь уг залбиралд хийгээд өмнөх илчлэлтүүдэд (64:23, 85:3, 97:11) зөвхөн аравны нэг хэмээн иш татагдсан төдийгүй харин Сүмийн санд оруулах бүх сайн дурын өргөлүүд эсвээс хандивууд гэсэн утгатай байжээ. Их Эзэн өмнө нь өргөлийн хууль болон үүрдийнх байхаар гэрээгээр түүнд гишүүдийн өргөсөн өмч хөрөнгийг эрхлэх хуулийг Сүмд өгсөн байлаа. Энэ гэрээг дагах нь олны хувьд бүтэхгүй байсны улмаас Их Эзэн үүнийг түр хугацаагаар буцаан татаж, мөн оронд нь аравны нэгийн хуулийг Сүм даяарт өгчээ. Тэдний өмч хөрөнгийн хичнээнийг нь ариун зарлигуудын тулд тэрээр шаарддагийг Бошиглогч Их Эзэнээс асуужээ. Хариулт нь энэ илчлэлт байлаа.

118 1а Үйлс 1:13, 16–17, 22–26.

2а су Томас Б.Марш.
3а су Даруу, Даруу

байдал.
б су Тэвчих.

1–5, Гэгээнтнүүд өөрсдийн илүү өмч хөрөнгийг төлж мөн тийнхүү аравны нэг болгон жил тутмын ашгийнхаа аравны нэгийг өгөх ёстой; 6–7, Ийм журам нь Сионы нутгийг ариусгах болно.

ҮНЭНЭЭР ийн Их Эзэн хэлж байна, тэдний бүх “илүү өмч хөрөнгө Сион дахь миний сүмийн бишопын гарт тавигдахыг би шаардаж байна.

2 Миний “өргөөг барихын тулд, мөн Сионы суурийг тавихын тулд мөн санваарын тулд, мөн миний Сүмийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн өрийн тулд болой.

3 Мөн энэ нь миний хүмүүсийн “аравны нэгийн эхлэл болой.

4 Мөн үүний дараа, ийнхүү аравны нэгийг төлөх тэд жил тутмын ашгийнхаа аравны нэг хэсгийг төлөх ёстой; мөн энэ нь миний ариун санваарын тулд тэдэнд үүрд үйлч-

лэх хууль байх ёстой хэмээн Их Эзэн хэлдэг.

5 Үнэнээр би та нарт хэлнэ, мөнхүү улиран тохиох дор “Сионы нутагт цуглах тэд бүгд илүү өмч хөрөнгөнөөсөө аравны нэгийг нь төлөх ёстой, мөн энэхүү хуулийг сахих ёстой, эс бөгөөс тэд та нарын дунд орших нь зохистой бус байх болно.

6 Мөн бибээр та нарт хэлнэ, хэрэв миний хүмүүс энэ хуулийг үл сахин, үүнийг ариунаар нь хадгалахгүй, мөн энэ хуулиар “Сионы нутгийг надад ариусгахгүй аваас, миний дүрмүүд хийгээд шүүлтүүд үүн дээр хадгалагдаж байхын тулд, энэ нь хамгаас ариун байж болохын тулд, болгоогтун, үнэнээр би та нарт хэлж байна, энэ нь та нарт Сионы нутаг байх нь үгүй бөлгөө.

7 Мөн энэ нь Сионы бүх “гадаснуудад үлгэр жишээ байх ёстой. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 120

1838 оны долдугаар сарын 8-нд Миссурийн Фар Вестэд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн, хэсэг 119 дэх өмнөх илчлэлтэд нэрлэгдсэн аравны нэгээр төлөгдсөн өмч хөрөнгийн мөн чанарыг мэдэгдсэн илчлэлт оршвой (History of the Church, 3:44).

ҮНЭНЭЭР ийн Их Эзэн хэлж байна, миний сүмийн Тэргүүн Зөвлөл мөн бишоп хийгээд түүний зөв-

лөлөөс бүрдсэн зөвлөлөөр, мөн миний дээд зөвлөлөөр мөн тэдэнд хандах миний өөрийн дуу хоолойгоор “энэ

119 1а С ба Г 42:33–34,
55; 51:13; 82:17–19.
2а С ба Г 115:8.
3а С ба Г 64:23;

Малах. 3:8–12.
су Аравны нэг
төлөх, Аравны нэг.
5а С ба Г 57:2–3.

6а су Сион.
7а су Гадас.
120 1а ө.х. Аравны нэг.

нь захиран зарцуулагддаг байх ёстой тэр цаг эдүгээ

иржээ хэмээн Их Эзэн хэлнэ. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 121

1839 оны гуравдугаар сарын 20-нд Миссурийн Либерти дахь шоронд хоригдол байхдаа Бошиглогч Иосеф Смитийн бичсэн залбирал ба бошиглолуд оршвой (History of the Church, 3:289–300). Бошиглогч хийгээд нилээд хэдэн хамтрагч нь олон сарын турш шоронд байлаа. Тэдний өргөдлүүд болон давж заалдах өргөдлүүд тэргүүлэх ажилтнуудад чиглэгдсэн бөгөөд шүүх тэднийг хөнгөвчилсөнгүй.

1–6, Зовж байгаа Гэгээнтнүүдийн төлөө Бошиглогч Их Эзэнээс гуйв; 7–10, Их Эзэн амар амгаланг түүнд ярив; 11–17, Их Эзэний хүмүүсийн эсрэг зөрчлийн тухай худал хуурмаг хашигирааныг дэгдээгч тэд бүгд зүхэгдсэн бөлгөө; 18–25, Тэд санваарын эрхгүй бөгөөд яллагдах болно; 26–32, Хүч зоригоор тэвчих тэдэнд алдар суут илчлэлтүүд амлагдав; 33–40, Яагаад олон нь дуудагдаж мөн цөөхөн нь сонгогддог вэ; 41–46, Санваар нь гагцхүү зөв шударга ёсонд хэрэглэгдэх ёстой.

Ай Бурхан минь, та хаана байна вэ, мөн таны “байгаа газрыг бүрхэгч тэрхүү асар хаана байна вэ?”

2 Таны гар “хичнээн удаан хүлцэн тэвчих юм бэ, мөн таны мэлмий, тийм ээ таны цэвэр ариун мэлмий өөрийн хүмүүсийн мөн өөрийн үйлчлэгчдийн буруу зүйлүүдийг мөнхийн тэнгэрээс болгоогооч, мөн тэдний гуйлтууд

сонорт тань хичнээн удаан нэвтрэх юм бэ?

3 Тийм ээ, Ай Их Эзэн минь, тэдэн уруу таны зүрх сэтгэл зөөлөрч, мөн таны дотор тэдэн уруу өрөвч сэтгэлээр хөдөлсөн байхаас өмнө тэд эдгээр буруу зүйлүүдийг мөн хууль бус доромжлолуудыг “хичнээн удаан тэвчих юм бэ?”

4 Ай “Бүхнийг Чадагч Бурхан, тэнгэр газар мөн далай тэнгисүүд, мөн тэдгээр дэх бүх зүйлийг бий болгогч, мөн чөтгөрийг, мөн Шеолын харанхуй хийгээд хар бараан эзэгнэлийг хянаж, мөн захирдаг Их Эзэн минь мутраа урагш сунгаач; мэлмий тань нэвт хараг; асраа босгооч; “байгаа газар тань дахиад бүү халхлагдаг; сонор тань нааш хандаг; зүрх сэтгэл тань зөөлрөг, мөн дотор тань биднийг өрөвдөх сэтгэлээр хөдлөг.

5 Уур тань бидний дайснуудын эсрэг дүрэлзэг; мөн, зүрх сэтгэлийнхээ догшин хилэнд, бидний эсрэг үйлдсэн

121 1a Дуул. 13:1–2; 102:1–2.

2a Хаб. 1:2. 3a С ба Г 109:49.

4a су Бүхнийг Чадагч. б С ба Г 123:6.

буруугийн төлөө “өс хонзонг маань илдээрээ аваач.

6 Ай бидний Бурхан Та, зовсон гэгээнтнүүдээ санаач; мөн таны үйлчлэгчид нэрэнд тань үүрд баясах болно.

7 Хүү минь, сүнсэнд чинь амар амгалан байг; “саад тотгор хийгээд зовлон зүдгүүрүүд чинь хэсэг хугацаанд байх болно;

8 Мөн тэгээд, хэрэв чи үүнийг дажгүй “давбал, Бурхан чамайг тэнгэрт өргөмжлөх болно; чи бүх дайснаа ялах болно.

9 “Найз нар чинь чиний дэргэд зогсох бөлгөө, мөн тэд халуун дотно сэтгэлээр мөн нөхөрсөг гараараа чамайг дахин мэндчилэх болно.

10 Чи “Иов шиг хараахан биш байгаа шүү дээ; тэд Иовт үйлдсэн шиг найз нар чинь чиний эсрэг тэмцээгүй, мөн чамд зөрчлийг тохсонгүй.

11 Мөн чамд зөрчлийг тохох тэд, тэдний итгэл найдвар нурах болно, мөн тэдний ирээдүйн төлөвлөгөөнүүд мандах нарны бүлээн туяанд “цан хяруу хайлдаг шиг хайлан замхрах болно.

12 Мөн түүний гайхамшигт үйлүүдийг ойлгохгүй байж болохын тулд; тэрээр түүнчлэн тэдгээрийг нотолж, мөн тэднийг өөрсдийнх нь заль мэхэнд тавьж болохын тулд

тэрчлэн “цаг хугацаа хийгээд улирлуудыг өөрчлөхийн тулд мөн тэдний оюуныг сохлохын тулд Бурхан гараа хөдөлгөж мөн тамгалсан бөлгөө;

13 Тэрчлэн тэдний зүрх сэтгэл ялзарсны улмаас, мөн бусад дээр тэд авчрахад бэлэн байгаа, мөн бусдыг зовоход дурладаг тэрхүү зүйлүүд тэдэн дээр “өөрсөд дээр нь бүр туйлын ихээр ирж болох бөлгөө;

14 Тэд тэрчлэн цөхрөнгөө барж, мөн итгэл найдвар нь тасарч болохын тулд буюу;

15 Үүнээс хойш олон биш жил болоход тэд хийгээд тэдний үр удам тэнгэрийн дороос арчигдах болно, тэднээс нэг нь ч хананы дэргэд зогсохоор үлдэх нь үгүй хэмээн Их Эзэн хэлж байна.

16 Миний “тослогдогсдын эсрэг өсгийгөө өргөх тэд бүгд, Их Эзэн хэлж байна, мөн тэд миний өмнө нүгэл үйлдээгүй байхад, харин тэдэнд миний зарлигласан миний мэлмийд нийцэхийг хийсэн байхад тэд “нүгэл үйлдлээ хэмээн хашгирагсад зүхэгдсэн болой хэмээн Их Эзэн хэлэв.

17 Харин тэд нүглийн үйлчэгчид, мөн өөрсдөө дуулгаваргүйн “хүүхдүүд учраас зөрчлийг хашгирдаг тэд үүнийг үйлддэг авай.

18 Мөн тэд боолчлол хийгээд үхэлд тэднийг авчирч

5a Лук 18:7–8.
7a су Дайсан.
8a 1 Петр 2:19–23.
су Тэвчих.
9a С ба Г 122:3.

10a су Иов.
11a Ег. 16:14.
12a Дан. 2:21.
13a Сур. үрс 28:10;
1 Ниф. 14:3.

16a 1 Сам. 26:9;
Дуул. 105:15.
б 2 Ниф. 15:20;
Моро. 7:14, 18.
17a Ефес 5:6.

болохын тулд миний үйлчлэгчдийн эсрэг хуурамчаар тангарлагч тэд болой —

19 Тэдэнд халаг; тэд миний балчир багачуудыг “томдоосон учраас тэд миний өргөөний” ёслолуудаас таслагдах болно.

20 Тэдний “сагс дүүрээгүй байх болно, тэдний гэр орон хийгээд тэдний саравчнууд сөнөх болно, мөн тэд өөрсдийг нь зусардах тэднээр өөрсдөө үзэн ядагдах болно.

21 Тэдэнд ч мөн тэдний дараах үр удамд нь ч гэсэн үеэс үед “санваарын эрх байхгүй байх болно.

22 Тэдний хувьд хүзүүндээ тээрмийн чулуу зүүгээд мөн далайн гүнд живсэн бол “дээр байсан юм.

23 Миний хүмүүсийн ая тухыг алдагдуулж, мөн хөөж, мөн амийг нь бүрэлгэн, мөн тэдний эсрэг гэрчилж буй тэд бүгдэд халаг хэмээн Түмний Их Эзэн хэлж байна; хорт могойн “үр удмынхан тамын ялнаас зайлах нь үгүй.

24 Болгоогтун, миний мэлмий бүх ажлыг “хардаг мөн мэддэг авай, мөн үүний зохих цагт, тэд бүгдэд зориулсан шуурхай” шүүлт надад нөөцөд буй;

25 Учир нь “ажлуудынх нь дагуу хүн болгонд” цаг нь өгөгдсөн болой.

26 Бурхан “Ариун Сүнсээрээ тийм ээ, өгүүлшгүй Ариун Сүнсний” бэлгээр дэлхий байхаас эдүгээг хүртэл илчлэгдээгүй байсан “мэдлэгийг та нарт өгөх болно;

27 Эцсийн өдрүүдэд илчлэгдэхийг нь бидний өвөг дээдэс итгэл тавин хүлээж байсан, тэнгэр элчүүдээр тэдний оюун үүнд чиглэгдсэн байсан, тэдний алдар суугийн бүрэн байдлын төлөө нөөцөд хадгалж байсан тэр зүйл нь буюу.

28 Нэг Бурхан уу эсвээс олон “бурхан байдаг уу гэдэг нь, цаг нь ирж” өгөгдөх зүйл юу ч үгүй болоход, тэдгээр нь илэрхийлэгдэх болно.

29 Есүс Христийн сайн мэдээний төлөө зоригтойгоор гэвчсэн тэд бүгдэд бүх хаан сэнтий хийгээд эзэгнэлүүд, вант улсууд хийгээд хүчнүүд “илчлэгдэж мөн толилуулагдах болно.

30 Мөн тэрчлэн, хэрэв тэнгэр хийгээд далай тэнгист, эсвээс хуурай газарт, эсвээс наранд, саранд эсвээс одод “хязгаар тавигдсан аваас —

31 Тэдний хувьслуудын

19a Мат. 18:6.
су Гомдоох.

б су Ёслолууд.
20a Дэд хууль 28:15–20.

21a су Санваартан.

22a Мат. 18:6;
С ба Г 54:5.

23a Мат. 12:34.

24a су Бүхнийг Мэдэгч.
б Хил. 8:25.

су Шүүх, Шүүлт.

25a су Ажлууд.

б Иов 7:1;
С ба Г 122:9.

26a С ба Г 8:2–3.

б су Ариун Сүнсний
бэлэг.

в Дан. 2:20–22; ИТ 1:9.

су Илчлэлт.

28a Дуул. 82:1, 6;

Иохан 10:34–36;

1 Кор. 8:5–6;

С ба Г 76:58; 132:20;

Абр. 4:1; 5:1–2.

б С ба Г 42:61;

76:7–8; 98:12.

29a С ба Г 101:32.

30a Иов 26:7–14;

Дуул. 104:5–9;

Үйлс 17:26.

бүхий л цагууд, тогтоогдсон бүх өдрүүд, сарууд, мөн он жилүүд, мөн тэдний бүх өдрүүдийн өдрүүд, сарууд, мөн он жилүүд, мөн тэдний бүх алдар суу, хуулиуд, мөн тогтоогдсон цагууд нь цаг хугацааны бүрэн байдлын “эрин үеийн өдрүүдэд илчлэгдэх болно —

32 Бүх бурхдын Мөнхийн “Бурханы ⁶Зөвлөлийн дунд энэ дэлхий байхаас өмнө томилогдсон тэр зүйлийн дагуу хүн болгон түүний мөнхийн ⁶оршихуйд мөн түүний үхэшгүй байдлын ‘амралтад ороход үүний эцэс хийгээд төгсгөлд хамгаалагдах болно.

33 Хуйлрагч уснууд хэр зэрэг удаан цэвэр биш үлдэж чадах билээ? Ямар хүч тэнгэрийг зогсоох билээ? Түүнчлэн Миссури мөрний жам ёсны урсгалыг хүмүүн өчүүхэн гараа урагш сунган зогсоох буюу эсвээс үүний урсгалыг эргүүлэх лугаа адил Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн тэргүүн дээр тэнгэрээс доош юүлэгдэх Бүхнийг Чадагчийн “мэдлэгт саад учруулж чадна гэж үү?

34 Болгоогтун, олон нь “дуудагддаг хэдий ч, цөөхөн нь

⁶сонгогддог бөлгөө. Мөн тэд юуны учир сонгогддоггүй вэ?

35 Учир нь тэдний зүрх сэтгэл энэ “дэлхийн зүйлүүд дээр нэн ихээр тавигдаж, мөн тэд энэ сургамжаас үл суралцан, хүмүүсээс ⁶хүндэтгэл хүлээхийг эрмэлздэг ажгуу —

36 Санваарын “эрхүүд нь тэнгэрийн ⁶хүчтэй салшгүй холбоотой байдаг, мөн тэнгэрийн тэрхүү хүч нь “зөв шударга ёсны зарчмуудаас бусдаар хянагдаж ч мөн шийдвэрлэгдэж ч үл чадах бөлгөө.

37 Тэдгээр нь бидэнд хүртээгддэг байж болох нь, энэ нь үнэн бөлгөө; харин бид “нүглээ ⁶далдлахыг оролдоход, эсвээс ⁶бардамналаараа, хоосон санаархлаараа сайрхах, эсвээс хүмүүний үрсийг хянах, эзэгнэх, эсвээс албадахад, болгоогтун, тэнгэр өөрийгөө ‘татан авдаг буюу; Их Эзэний Сүнс гашууддаг болой; мөн энэ нь буцаан таагдахад, тэр хүний санваарт эсвээс эрх мэдэлд Амен.

38 Болгоогтун, төдөлгүй тэрээр ухаарахад, шилбүүрийн эсрэг “өшиглөхөөр, гэгээнтнүүдийг ⁶мөрдөн хавчихаар Бурханы эсрэг тулал-

31a су Эрин үе.

32a Дэд хуул 10:17.

б су Тэнгэр дэх Зөвлөл.

в су Хүмүүн, Хүмүүс—Хүн, Тэнгэрлэг Эцэгтэй адил болох боломж.

г су Амрах.

33a С ба Г 128:19.

су Мэдлэг.

34a Мат. 20:16; 22:1–14;

С ба Г 95:5–6.

су Дуудах, Бурханаас дуудагдах, Дуудлага.

б су Сонгосон.

35a су Дэлхийнх.

б Мат. 6:2;

2 Ниф. 26:29.

36a су Санваартан;

Эрх мэдэл.

б су Хүч.

в су Зөв шударга, Зөв шударга ёс.

37a су Нүгэл.

б Сур. үгс 28:13.

в су Бардамнал.

г С ба Г 1:33.

38a Үйлс 9:5.

б су Хавчих,

Хавчлага.

дахаар тэрээр ганцаараа үлддэг буюу.

39 Тэд бага ч гэсэн эрх мэдэлтэй боллоо хэмээн өөрсдөө бодмогцоо, тэр даруй тэд шударга бусаар эзэгнэж эхлэх болно гэдэг нь бараг бүх хүний “мөн чанар хийгээд авир төрх юм гэдгийг бид гунигтай туршлагаар мэдэж авлаа.

40 Иймээс олон нь дуудагдаг хэдий ч, цөөхөн нь сонгогддог болой.

41 Хүч буюу нөлөө нь санваарын ариун журмаар төдийгүй гагцхүү “сэнхрүүлээр, ^бтэсвэр тэвчээрээр, эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөнөөр, чин сэтгэлийн хайраар тэтгэгдэж чадах буюу байх ёстой ажгуу;

42 Нинжин сэтгэл, мөн цэвэр мэдлэгээр энэ нь “зусардалтгүйгээр мөн ^бзаль мэхгүйгээр оюун санааг агуу ихээр өргөжүүлэн тэлдэг буюу —

43 Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн үед хурц тодоор, цагаа олж “шүүмжил; мөн тэрээр чамайг дайснаа гэж үзэхгүйн

тулд, тэгээд та нар шүүмжилсэн түүнийг хайрлах ^бхайраа дараа нь нэмэгдүүлснээ харуул.

44 Чиний итгэлтэй байдал үхлийн хүлээснээс илүү хүчтэйг тэрээр мэдэж болохын тулд буюу.

45 Хэвлий дотор чинь тэрчлэн бүх хүмүүнд, мөн итгэлийн тогтмол байдалд энэрлээр дүүрэн байг, мөн “бодол санааг чинь ^бариун журам зогсолтгүй чимэн гоёг, тийнхүү итгэлтэй байдал чинь Бурханы оршихуйд хүчтэй болох болно, мөн санваарын номлол тэнгэрээс буух “шүүдэр лугаа адил чиний сүнсэн дээр намуухан буух болно.

46 “Ариун Сүнс чиний байнгын хамтрагч мөн чиний очирт таяг, зөв шударга ёс хийгээд үнэний хувиршгүй очирт таяг байх болно, мөн эзэгнэл чинь үүрдийн ^бээгнэл байх болно, мөн албадлагын арга хэрэгсэлгүйгээр энэ нь чам уруу үүрд мөн мөнхөд урсах болно.

ХЭСЭГ 122

1839 оны гуравдугаар сард Миссурийн Либерти шоронд хоригдол байхад нь Бошиглогч Иосеф Смитэд хандсан Их Эзэний үг оршвой (History of the Church, 3:300–301).

1–4, Дэлхийн хязгаарууд Иосеф Смитийн нэрийг асуун сураглах

болно; 5–7, Түүний бүхий л аюул ослууд хийгээд зовлон зүдгүүрүүд

39а су Эгэл хүн.
41а 1 Петр 5:1–3.
б 2 Кор. 6:4–6.
42а Иаков 3:17.
б су Заль мэх.

43а су Зэмлэх, Зэмлэл.
б су Энэрэл; Хайр.
45а су Бодлууд.
б су Нөлөөлөх хүч.
в Дэд хууль 32:1–2;

С ба Г 128:19.
46а су Ариун Сүнс.
б Дан. 7:13–14.

түүнд туршлага суулгаж мөн түүний сайн сайхны төлөө байх болно; 8–9, Хүний Хүү тэр бүгдийн доор доош бууж ирэв.

ДЭЛХИЙН хязгаарууд чиний “нэрийг асууж сураглах болно, мөн мунхгууд чамайг элэг доог болгох болно, мөн там чиний эсрэг уурлан хилэгнэх болно;

2 Нөгөө талаар зүрх сэтгэлдээ цэвэр ариун тэд мөн ухаалаг бас шударга, мөн ариун журамтай “зөвлөгөө, мөн эрх мэдэл, бас адислалуудыг чиний гар дороос байнга эрэлхийлэх болно.

3 Мөн чиний хүмүүс чиний эсрэг урвагчдын гэрчлэлээр хэзээ ч эргэх нь үгүй.

4 Мөн тэдний нөлөө чамайг төвөг бэрхшээлд, мөн торонд болон хананд хаях хэдий ч, чи нэр төртэй байх болно; мөн харин багахан “хугацаанаас бусад үед мөн чиний дуу хоолой, зөв шударгын чинь учир дайснуудын чинь дунд догшин ⁶арслангаас илүү аймшигтай байх болно; мөн чиний Бурхан дэргэд чинь үүрд мөн мөнхөд зогсох болно.

5 Хэрэв чи гай зовлон дундуур туулахаар дуудагдсан аваас; хэрэв чи хуурамч ах дүүсийн дунд зовлон зүдгүүрүүдэд байгаа аваас; хэрэв чи дээрэмчдийн дунд зовлон зүдгүүрүүдэд байгаа аваас;

хэрэв чи газраар, эсвээс далайгаар зовлон зүдгүүрүүдэд байгаа аваас;

6 Хэрэв чи бүхий л төрлийн хуурмаг ялуудаар яллагдаж байгаа аваас; хэрэв дайснууд чинь чам дээр унах аваас; хэрэв тэд чамайг эцэг болон эх мөн ах болон эгч дүүсээс чинь салгах аваас; мөн хэрэв илдээ сугалсан дайснууд чинь чамайг эхнэрийн чинь цээжнээс, мөн өмсгөлүүдэд чинь наалдан, мөн аав минь, аав минь та яагаад бидэнтэй хамт үлдэж болохгүй байгаа юм бэ? Ай аав минь, тэр хүмүүс таныг яах гэж байгаа юм бэ? гэж хэлэх ердөө зургаахан настай, мөн ууган хүүгээс чинь салгах аваас, мөн тэгээд хэрэв тэрээр илдээр чамаас тас цохигдох аваас, мөн чи шоронд хүчээр чирэгдэн очих аваас, бас хурганы цусны төлөө “чононууд лугаа адил дайснууд чинь чиний эргэн тойронд хөлхөлдөх болно;

7 Мөн хэрэв чи нүхэнд, эсвээс алуурчдын гарт чам дээр тохиох үхлийн яланд хаягдах ёстой аваас; хэрэв чи “гүнд хаягдах аваас; хэрэв хүрхрэх далайн давалгаа чиний эсрэг хуйвалдах аваас; хэрэв догшин салхи чиний дайсан болох аваас; хэрэв тэнгэр хар барааныг цуглуулж, мөн бүх элементүүд замыг хүрээлэн хаахаар

122 1a ИС—Т 1:33.

2a су Зөвлөгөө.

4a С ба Г 121:7–8.

б 3 Ниф. 20:16–21;

21:12.

6a Лук 10:3.

7a Иона 2:3–6.

нэгдэх аваас; мөн бүхний дээгүүр, хэрэв ^бтамын эрүү чиний араас амаа томоор ангайлгах аваас, эдгээр бүх зүйл чамд ^втуршлага суулгах болно, мөн чиний сайн сайхны төлөө байх болно гэдгийг чи мэдэгтүн, хүү минь.

8 Хүний “Хүү тэд бүгдэд доош ^ббууж ирсэн юм. Чи түүнээс илүү агуу гэж үү?

9 Тиймийн тул, зам дээрээ

зогсогтун, мөн санваар чамтай хамт “үлдэх болно; учир нь, тэдний ^бхязгаар тогтоогдож, тэд өнгөрч чадахгүй. Чиний ^вөдрүүд мэдэгдсэн билээ, мөн чиний он жилүүд багаар тоологдох нь үгүй; тиймийн тул, хүний хийж чадах юмнаас бүү ‘эмээ, учир нь Бурхан чамтай үүрд мөн мөнхөд хамт байх болно.

ХЭСЭГ 123

1839 оны гуравдугаар сард Либерти шоронд хоригдол байх үед нь Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өөрсдийг нь мөрдөн мөшгөгчдийн талаар өгөгдсөн илчлэлтэд толилуулагдсан Гэгээнтнүүдийн үүрэг оршвой (History of the Church, 3:302–303).

1–6, Гэгээнтнүүд өөрсдийн зовлонгууд мөн хавчлагуудын шастирьг цуглуулж мөн нийтлүүлэх ёстой; 7–10, Хуурамч итгэлийг бий болгосон тэрхүү сүнс тэрчлэн Гэгээнтнүүдийг мөшгихөд удирддаг; 11–17, Бүх бүлэглэлүүдийн дундах олон нь үнэнийг чухамхүү хүлээн авах болно.

МӨН дахин, энэ Муж Мулсын хүмүүсээр тэдэн дээр тавигдсан зовлон хэлмэгдлүүд хийгээд доромжлолууд, мөн бүх гэгээнтнүүдийн бүх баримтын мэдлэгийг цуглуулах тухай анхааралдаа авахыг бид санал болгомоор байна;

2 Мөн тэрчлэн бүх өмч хөрөнгийн тухай мөн хүний хийгээд зан чанар аль алиных нь бэртэл гэмтлүүд мөн түүнчлэн үл хөдлөх хөрөнгийн талаарх эвдрэлийн тоо хэмжээг буюу;

3 Мөн тэрчлэн тэднийг доромжлоход гар бие оролцсон бүх хүмүүсийн нэрсийг тэднээс олж авч, бас үүнчлэн тэдгээрийг мэдэж авч болох бөлгөө.

4 Мөн эдгээр зүйлүүдийг олж авах мөн нотолгоонууд хийгээд албан мэдүүлгүүдийг олж авах мөн тэрчлэн эдүгээ гарч байгаа гүжир гүтгэлгийн нийтлэлүүдийг цуглуулах

7б 2 Сам. 22:5–7;
 ИС—Т 1:15–16.
 в 2 Кор. 4:17;
 Евр. 12:10–11;
 2 Ниф. 2:11.
 8а су Хүний Хүү.

б Евр. 2:9, 17–18;
 С ба Г 76:107; 88:6.
 9а С ба Г 90:3.
 б Үйлс. 17:26.
 в С ба Г 121:25.
 г Нех. 4:14;

Дуул. 56:4; 118:6;
 Сур. үгс 3:5–6;
 Иса. 51:7;
 Лук 12:4–5;
 2 Ниф. 8:7;
 С ба Г 3:7; 98:14.

хороо томилогдох боломжтой бөлгөө;

5 Мөн сэтгүүлүүдэд бас нэвтэрхий толь бичгүүдэд нийтлэгдэж байгаа гүжир гүтгэлгийн бүх түүх, мөн тэдний бичиж, мөн толилуулдаг чөтгөрийн санаат луйвар мөн энэ хүмүүс дээр хэрэглэж буй бусармаг хийгээд алан хядах ажиллагааны бүхий л хоорондоо холбоотой байдлыг буюу —

6 Бид үүнийг бүх дэлхийд мэдэгдэж болох төдийгүй, харин тэдгээрийг тэдний харанхуйд хийгээд тамын аяст нь засгийн газрын тэргүүнүүдэд танилцуулж бидний Тэнгэрлэг Эцэг бидний талаар тавьсан сүүлчийн тэрхүү хүчин чармайлтын учир түүний “нуугдан байгаа газраас түүнийг урагш дуудах амлалтыг өмнө нь бид бүрэн хийгээд дүүрнээр нэхэж болохын тулд болой; мөн тэрчлэн тэрээр хүчирхэг гарынхаа чадлыг урагш илгээхээс өмнө бүхэл үндэстэн шалтаггүйгээр үлдэж болохын тулд буюу.

7 Бид Бурханд, тэдэнтэй хамт зогсохоор бидний аваачигдах тэнгэр элчүүдэд, мөн түүнчлэн өөрсдөдөө, хүүхдүүдийнхээ зүрх сэтгэлд худал хуурмагийг өвлөн авсан эцгүүдийнх нь сүсэг бишрэлд ихэд хүчтэйгээр шигдсэн тэрхүү сүнсний нөлөөгөөр тэтгэгдэн, мөн урамшуулагдаж бас хөхиүлэн дэмжигдэн, хамгийн ихээр хараал идсэн

аллагын гар, харгислал хийгээд доромжлол, гомдол, уй гашуу дор, түүнчлэн хүнд ачаа дарамтанд толгой гудайх болгогдсон эхнэр хийгээд хүүхдүүддээ өр төлөөстэй нь бидэнд тохоогдсон үүрэг хариуцлага юм, мөн дэлхий төөрөгдлөөр дүүрч, энэ нь улам бүр хүчтэй болж байна, мөн дэлхий эдүгээ бүхий л ялзралын чухамхүү хөдөлгөгч эх үүсвэр болж, мөн бүхэл “газар дэлхий алдсынхаа хүндийн дор ёолж байна.

8 Энэ бол төмөр “буулга болой; энэ бол хүчтэй хүлээс бөлгөө; тэдгээр нь үнэхээр гав, мөн гинж, мөн дөнгө, мөн тамын хөлийн дөнгө болой.

9 Тиймийн тул, бид зөвхөн эхнэр болон хүүхдүүддээ төдийгүй түүнчлэн төмөр нударган дор нөхрүүд хийгээд эцгүүд нь “алагдсан бэлэвсэн эхнэрүүд хийгээд эцэггүй үлдэгсдэд өртэй байгаа нь бидний заавал биелүүлэх үүрэг болой.

10 Энэ харанхуй хийгээд бараантуулагч үйлс нь тамыг өөрийг нь дагжин чичирч мөн хэрдхийн цочиж мөн зэвхий царайлан зогсоход, мөн чухам тэрхүү чөтгөрийн гар чичирч мөн салгалах болгоход хангалттай бөлгөө.

11 Мөн тэрчлэн бид өсч өндийн байгаа бүх үеийнхэнд, зүрх сэтгэлдээ цэвэр ариун тэд бүгдэд өртэй

байгаа нь заавал биелүүлэх үүрэг болой—

12 Учир нь дэлхий даяар бүх бүлэглэлүүд, намууд хийгээд хүсэг бишрэлүүдийн дунд хүмүүний овжин заль мэхээр “харалган болж, үүгээр тэд мэхлэхийг хүлээн худал хэлдэг, мөн тэд үүнийг хаанаас олохыг ⁶мэддэггүйн улмаас гагцхүү үнэнээс хол байдаг нь олон буй—

13 Тиймийн тул, тэдгээрийг хаана байгааг нь бид мэддэг харанхуйн бүх “нуугдсан зүйлүүдийг гэрэлд авчрахад бид амдралаа зориулж мөн элээх учиртай ажгуу; мөн тэдгээр нь жинхэнэ ёсоор тэнгэрээс үзүүлэгддэг болой—

14 Эдгээр нь тийнхүү агуу их шаргуу чанартай дагалдах ёстой.

15 Хүмүүн тэдгээрийг жижиг зүйлүүд хэмээн бүү тооцог; учир нь эдгээр зүйлүүдээс хамаарах, гэгээнтнүүдэд холбогдох ирээдүйд орших их зүйл тэнд буй.

16 Шуурганы үед маш том хөлөг онгоц нэн жижигхэн залууртай явснаар салхи хийгээд давалгаатай зохицолдон нэн их “ашигтай байдгийг, ах дүүс минь та нар мэднэ.

17 Тиймийн тул, эрхэм хайрт ах дүүс минь, өөрсдийн хүчинд байгаа бүх зүйлийг “хөгжил хөөртэйгөөр хийцгээе; мөн тэгээд бид бат итгэлтэйгээр бат зогсож Бурханы ⁶авралыг харна, мөн учир нь түүний гар илчлэгдэх болно.

ХЭСЭГ 124

1841 оны нэгдүгээр сарын 19-нд Иллинойн Наувуд Бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 4:274–286). Мөрдлөг хавчлага мөн тэдний эсрэг төрийн ажилтнуудын хууль бус явууллага өссөний улмаас, Миссурийг орхиж явахыг Гэгээнтнүүдэд албадан тулгажээ. 1838 оны аравдугаар сарын 27-ны өдөр Миссурийн захирагч Лилбурн В.Боггсын гаргасан сүйрүүлэгч энэ тушаал тэдэнд сонгох өөр замыг олгосонгүй (History of the Church, 3:175). Энэ илчлэлт өгөгдсөн 1841 онд Иллинойд, Коммерс тосгон байсан газар дээр Наувугийн хот Гэгээнтнүүдээр баригдаж, мөн энд Сүмийн төв удирдлага үндэслэгдэн бий болжээ.

1–14, Нэгдсэн Улсын ерөнхийлөгч, захирагчид мөн бүх үндэстний удирдагчдад сайн мэдээг чин сэтгэлээсээ тунхаглахыг Иосеф Смитэд зарлиг

болгов; 15–21, Хайрум Смит, Давид В.Паттен, Ахмад Иосеф Смит болон бусад амьд болон нас барагсдын дунд буй хүмүүс өөрсдийн шударга ёс ба ариун

12a Кол. 2:8;
С ба Г 76:75.
б 1 Ниф. 8:21–23.

13a 1 Кор. 4:5;
16a Иаков 3:4;
Алма 37:6–7;

С ба Г 64:33.
17a С ба Г 59:15.
б Ег. 14:13.

журмын учир адислагдсан болой; 22-28, Гадныхны орон байрны тулд байрыг мөн ариун сүмийг аль алиныг нь Наувуд барихыг Гэгээнтнүүдэд зарлиглав; 29-36, Нас барасдын өмнөөс хийлгэх баптисмууд ариун сүмүүдэд гүйцэтгэгддэг байх ёстой; 37-44, Их Эзэний хүмүүс ариун ёслолуудыг гүйцэтгэхийн тулд ариун сүмүүдийг ямагт барьдаг; 45-55, Дайснуудынх нь хавчлага доромжлолын улмаас Гэгээнтнүүд Жаксон гүнлэгт ариун сүм барихаас чөлөөлөгдөв; 56-83, Наувугийн Өргөө барих талаар чиглэлүүд өгөгдөв; 84-96, Хайрум Смит түлхүүрүүдийг хүлээн авахаар мөн Оливер Каудерийн оронд зогсож, патриарх байхаар дуудагдав; 97-122, Виллям Лоо болон бусад нь өөрсдийн хөдөлмөрүүдэд зөвлөгдөв; 123-145, Ерөнхий болон орон нутгийн ажилтнууд өөрсдийн үүргүүд хийгээд харьяалагддаг чуулгуудын хамт нэрлэгдэв.

ҮНЭНЭЭР ийн Их Эзэн Өөрийн үйлчлэгч Иосеф Смитэд хэлж байна, чиний хийсэн өргөл хийгээд хүлээн зөвшөөрөлтүүд миний таашаалд нийцлээ; учир нь дэлхийн “сул дорой зүйлүүдээр дамжуулан бибээр мэргэн ухаанаа үзүүлж болохын тулд би энэ төгсгөлд чамайг бэлтгэсэн билээ.

2 Залбирлууд чинь миний өмнө хүлээн авагдахуйц бо-

лой; мөн тэдгээрт хариулан би чамд хэлж байна, чи миний сайн мэдээг, мөн ордны маягаар засан сайжруулснаар өнгөлөгдөх Сионы суурийн чулуу байхаар миний үндэслэсэн энэхүү “гасны тухай нэн даруй чин сэтгэлээсээ тунхаглахаар дуудагдсан болой.

3 Энэхүү тунхаглал дэлхийн бүх “хаадад, үүний дөрвөн хязгаарт, цэх шударга сонгогдсон ерөнхийлөгчид, мөн чиний амьдарч буй үндэстний хүндэт захирагчдад мөн гадаад дэлхийд тараагдсан бүх үндэстнүүдэд хийгдэх ёстой.

4 Энэ нь мөнхүү үүнийг бичих үед чамд байх Ариун Сүнсний хүчээр мөн “номхон дөлгөөн байдлын сүнсэнд бичигдэг;

5 Учир нь тэдгээр хаад хийгээд эрх баригчдын талаарх миний тааллыг, бүр ирэх цагт тэдэнд юу тохиохыг мэдэхэд нь чамд Ариун Сүнсээр өгөгдөх болно.

6 Учир нь, болгоогтун, Сионы гэрэл хийгээд алдар сууд анхаарал тавихад би тэднийг дуудах гэж байна, учир нь үүний тусын тулд тогтоосон тэрхүү цаг ирлээ.

7 Тиймийн тул, тэд тэрчлэн шалтаггүйгээр үлдэхийн тулд та нар тэднийг чанга тунхаглалаар мөн өөрсдийн гэрчлэлээр, тэднээс айлгүйгээр дуудагтун, учир нь

124 1a 1 Кор. 1:26-28;
С ба Г 1:19; 35:13.
2a су Гадас.

3a Дуул. 119:46;
Мат. 10:18;
С ба Г 1:23.

4a су Номхон
дөлгөөн, Номхон
дөлгөөн байдал.

тэд “өвс лугаа адил юм, мөн тэдний бүхий л алдар суу удалгүй гандах үүний цэцэг лугаа адил юм—

8 Мөн хэрэв тэд үйлчлэгчдийг минь хийгээд тэдэнд миний илчилсэн гэрчлэлийг минь эсэргүүцэх үед, шүдээ “хавирах тэрхүү хоёр нүүрт-нүүдийн дундах доромжлогчийн хувийг хүртээхээр би нүүрнийхээ халхавчийг сөхөх айлчлалын тэрхүү өдөрт бибээр тэдэнд айлчилж болохын тулд буюу.

9 Мөн дахин, би айлчилж мөн тэдний зүрх сэтгэлийг зөөлрүүлэх болно, та нар тэдний мэлмийд ач ивээлийг олж болохын тулд, тэд үнэний “гэрэлд, мөн харийнхан Сионы өргөмжлөл буюу өргөлтөд ирж болохын тулд тэдний олон нь та нарын сайн сайхны төлөө байх болой.

10 Учир нь миний айлчлалын өдөр та нарын бодоогүй “цагт үтэр түргэн ирэх болой; мөн миний хүмүүсийн аюулгүй байдал хийгээд тэднээс үлдэх тэдэнд хоргодох байр хаана байх ёстой вэ?

11 Ай дэлхийн хаад аа, сэ-рэгтүн! Өөрсдийн алт мөн өөрсдийн мөнгөтэйгөөр миний хүмүүст, Сионы охидын өргөөнд туслахаар ирээч та нар, Ай, ирээч та нар.

12 Мөн дахин, үнэнээр би чамд хэлж байна, миний үйлчлэгч Роберт Б.Томпсон энэ тунхаглалыг бичихэд чамд туслаг, учир нь тэрээр, мөн тэрээр чамтай хамт байх нь миний таашаалд нийцдэг билээ;

13 Тэрээр, тиймийн тул, зөвлөгөөг чинь сонсог, мөн бибээр түүнийг үй олон адислалаар адислах болно; үүнээс хойш тэрээр бүх зүйлд итгэлтэй мөн үнэнч байг, мөн тэрээр миний мэлмийд агуу байх болно;

14 Харин “ажил үүргийг нь би түүний гараас шаардах болно гэдгийг тэрээр санаг.

15 Мөн дахин, үнэнээр би чамд хэлж байна, адислагдсан болой миний үйлчлэгч “Хайрум Смит; учир нь зүрх сэтгэлийнх нь “үнэнч шударгын учир мөн миний өмнө зөв болох зүйлийг тэрээр хайрладгийн учир Их Эзэн бибээр түүнийг хайрладаг билээ хэмээн Их Эзэн бибээр хэлж байна.

16 Дахин, миний үйлчлэгч Жон К.Беннет дэлхийн хаад хийгээд хүмүүст миний үгийг илгээх хөдөлмөрт чинь тусалж, мөн чиний бүр миний үйлчлэгч Иосеф Смит чиний дэргэд, зовлон зүдгүүрийн цагт зогсог; мөн хэрэв тэрээр “зөвлөгөөг хүлээн авбаас,

7a Дуул. 103:15–16;

Иса. 40:6–8;

1 Петр 1:24–25.

8a Мат. 8:12;

Алма 40:13;

С ба Г 101:91; 112:24.

9a Иса. 60:1–4.

су Гэрэл, Христийн гэрэл.

10a Мат. 24:44;

ИС—А 1:48.

14a су Даамал, Ажил

үүрэг.

15a су Смит Хайрум.

б су Зарчимч байдал.

16a су Зөвлөгөө.

шагнал нь бүтэмжтэй байх болно.

17 Мөн тэрээр хайрынхаа улмаас агуу байх болно, учир нь хэрэв тэрээр үүнийг хийх аваас, тэрээр минийх байх болно хэмээн Их Эзэн хэлж байна. Түүний хийсэн ажлыг би үзсэн бөлгөө, хэрэв тэрээр үргэлжлүүлэх аваас, би үүнийг хүлээн авч, мөн адислалууд хийгээд алдар суугаар түүнийг титэмлэх болно.

18 Мөн дахин миний үйлчлэгч Лайман Вайт номхон дөлгөөн байдлын сүнсэнд, дэлхийн өмнө намайг хүлээн зөвшөөрүүлж, Сионы тулд номлолоо үргэлжлүүлэх нь миний таалал билээ гэдгийг би чамд хэлж байна; мөн бибээр түүнийг “бүргэдийн далавчин дээр лугаа адил авч явах болно; мөн тэрээр миний нэрэнд өөртөө алдар суу хийгээд хүндэтгэлийг бий болгох болно.

19 Түүнийг ажлаа дуусгахад, энэ цагт надтай хамт байгаа миний үйлчлэгч “Давид Паттен, мөн тэрчлэн миний үйлчлэгч “Эдвард Партриж, мөн тэрчлэн энэ цагт “Абрахамтай хамт түүний баруун гарт сууж буй ариун бөгөөд адислагдсан миний ахимаг настай үйлчлэгч Ахмад “Иосеф Смитэд үйлдсэний адилаар би түүнийг өөртөө

хүлээн авч болохын тулд буюу, учир нь тэрээр минийх бөлгөө.

20 Мөн дахин, үнэнээр би чамд хэлж байна, миний үйлчлэгч Жорж Миллер “заль мэхгүй болой; зүрх сэтгэлийнхээ үнэнч шударгын учир тэрээр итгэмжлэгдэж болох бөлгөө; мөн надаас ирэх гэрчлэлд тэрээр хайртайн учир Их Эзэн, бибээр түүнийг хайрладаг бөлгөө.

21 Би тиймийн тул чамд хэлж байна, тэрээр миний өргөөний өргөлийг хүлээн авч болохын тулд, тэрээр миний хүмүүсийн ядуугийнх нь тэргүүн дээр адислалуудыг өгөхийн тулд, бибээр өөрийн үйлчлэгч Эдвард Партрижид өгсний адилаар “бишопын зөвлөлийн албан тушаалыг түүний тэргүүн дээр лацдаж байна. Миний үйлчлэгч Жоржийг хүмүүн бүү үл тоомсорлог, учир нь тэрээр намайг хүндэтгэх болно.

22 Миний үйлчлэгч Жорж, мөн миний үйлчлэгч Лайман, мөн миний үйлчлэгч Жон Снайдер, түүнчлэн бусад нь миний үйлчлэгч Иосефын тэдэнд үзүүлсний дагуу, тэрчлэн тэдэнд түүний үзүүлэх газар дээр миний нэрэнд тийм нэг байр “бариг.

23 Мөн энэ нь хоноглох байр, гадныхан холоос ирж байрлах байр байх болно; тиймийн

18a Ег. 19:4; Иса. 40:31.

19a С ба Г 124:130.

су Давид В.Паттен.

б су Эдвард

Партриж.

в С ба Г 137:5.

г су Ахмад Иосеф

Смит.

20a су Заль мэх.

21a С ба Г 41:9.

су Бишоп.

22a С ба Г 124:56-60.

тул энэ нь ядарсан “аянчин Их Эзэний үгийг, мөн Сионы төлөө ⁶суурийн чулууг би тогтоож өгснийг бясалган бодох үедээ эрүүл хийгээд аюулгүй байдлыг олж болохын тулд бүх талаараа хүлээн зөвшөөрөгдөхүйц зохистой, сайн байр байг.

24 Хэрэв энэ нь миний нэрэнд баригдах аваас, мөн үүнд томилогдох захирагч үүнд аливаа бохир зүйл орохыг хүлцэхгүй байх аваас энэ байр эрүүл саруул сууц байх болно.

25 Мөн дахин, үнэнээр би чамд хэлж байна, миний бүх гэгээнтнүүд холоос ирэг.

26 Мөн та нар шуурхай элчүүдийг, тийм ээ, сонгогдсон элчүүдийг илгээж, мөн тэдэнд хэлэгтүн: Ирцгээ та нар, өөрсдийн бүх алттайгаар, мөн өөрсдийн мөнгөтэйгөөр, мөн өөрсдийн бүх эртний эдлэлүүдтэйгээр мөн эртний эдлэлүүдийн талаар мэдлэгтэй ирэх хэн боловч ирэг, мөн шинэс мод, мөн гацуур мод, мөн нарс модыг дэлхийн бүх үнэт моднуудын хамт авчрагтун;

27 Мөн төмөртэйгөөр, зэстэйгээр, мөн гуультайгаар мөн цайртайгаар, мөн дэлхийн бүх үнэт зүйлстэйгээ буюу; мөн миний нэрэнд “өргөө баригтун, учир нь

үүн дотор Бүхнээс Дээд нь ⁶орших буюу.

28 Учир нь тэрээр ирж мөн та нарт алдагдсан, эсвээс тэрээр аваачсан тэр зүйлийг бүр санваарын бүрэн байдлыг “сэргээж болох газар, дэлхий дээр байхгүй байна.

29 Учир нь тэд, миний гэгээнтнүүд нас барсан тэдний өмнөөс “баптисм хүртэж болох ⁶баптисмын сан дэлхий дээр байхгүй байна.

30 Учир нь энэхүү ёслол миний өргөөнд хамаардаг билээ, та нар надад өргөө барьж чадахааргүй ядуу зүдүүгийн чинь өдрүүдээс бусад үед миний хувьд хүлээн авагдахуйц байж чадахгүй болой.

31 Гэвч надад өргөө “барихыг би бүх гэгээнтнүүддээ зарлиглаж байна; мөн надад өргөө барих хангалттай цагийг би та нарт өгье; мөн энэ үед та нарын баптисмууд миний хувьд хүлээн авагдахуйц байх болно.

32 Харин болгоогтун, энэ томилолтын төгсгөлд та нарын нас барагсдын төлөөх баптисмууд чинь миний хувьд хүлээн авагдахуйц байх нь үгүй бөлгөө; мөн хэрэв та нар уг томилолтын төгсгөлд эдгээр зүйлүүдийг эс хийх аваас, та нар өөрсдийн нас барагсадтайгаа хамт сүмийн

23a Дэд хууль 31:12; Мат. 25:35, 38.

б С ба Г 124:2.

27a С ба Г 109:5.

су Ариун Сүм, Их Эзэний Өргөө.

б Ег. 25:8;

С ба Г 97:15–17.

28a су Сайн мэдээний сэргээлт.

29a 1 Кор. 15:29;

С ба Г 127:6; 138:33.

су Баптисм,

Баптисм хүртээх—

Нас барагсдын төлөөх баптисм; Нас барагсдын аврал.

б С ба Г 128:13.

31a С ба Г 97:10.

хувьд няцаагдах болно хэмээн Их Эзэн та нарын Бурхан хэлж байна.

33 Учир нь үнэнээр би та нарт хэлж байна, нас барагсдын өмнөөс хийх баптисмын ёслолд хамаардаг өргөөг та нар надад барих хангалттай цагтай болсны дараа, мөнхүү энэ нь дэлхийн сууринаас өмнө үндэслэгдсэний учир, нас барагсдын чинь төлөөх та нарын баптисмууд миний хувьд хүлээн авагдахуйц байж чадахгүй;

34 Учир нь та нар хүндэтгэл хийгээд алдар сууг хүлээн авч болохын тулд тэнд ариун санваарын “түлхүүрүүд олгогддог.

35 Мөн энэ цагийн дараа нас барагсдын өмнөөс алс холд тараагдсан тэднээр хийгдэх та нарын баптисмууд надад хүлээн авагдахуйц биш болой хэмээн Их Эзэн хэлж байна.

36 Учир нь Сионд, мөн үүний бүх гадаснуудад, мөн Иерусалимд, “хоргодох байрны тулд миний тогтоосон тэдгээр газрууд нь, та нарын нас барагсдын өмнөөс хийлгэх та нарын баптисмын газрууд байхад зориулагддаг болой.

37 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлнэ, миний нэрэнд та нарын барьсан өргөөнд тэд-

гээрийг та нар гүйцэтгэхээс бусдаар, та нарын “угаалгууд, миний хувьд хэр зэрэг хүлээн авч болохуйц байх вэ?

38 Учир нь, энэхүү шалтгааны учир дэлхий байхаас өмнө нуугдмал байсан тэдгээр ёслолууд илчлэгдэж болохын тулд тэрээр “асар барьж, тэд үүнийг өөрсөдтэйгөө хамт аглаг буйдад авч яван, мөн амлалтын нутагт ^бөргөө барих ёстой хэмээн Мосед би зарлигласан билээ.

39 Тиймийн тул, үнэнээр би та нарт хэлж байна, та нарын “тосолгоонууд мөн та нарын угаалгууд, нас барагсдын төлөөх та нарын ^ббаптисмууд, нас барагсдын төлөөх та нарын “онцгой ариун хуралдаинууд мөн та нарын ‘золиослолуудын төлөө Левийн хөвгүүдээр хийгдсэн та нарын дурсгалууд, мөн харилцааг та нар хүлээн авдаг хамгийн ^аариун газрууд дахь та нарын төлөөх илчлэгдсэн зөгнөлүүд, мөн Сионы суурь хийгээд илчлэлтүүдийн эхлэлийн тулд мөн миний ариун нэрэнд барихаар миний хүмүүст ямагт зарлигладаг миний ариун өргөөний ёслолоор тогтоогддог түүний бүх оршин суугчдын алдар суу, хүндэтгэл мөн хишгийн

34a С ба Г 110:14–16.

су Санваарын
түлхүүрүүд.

36a Иса. 4:5–6.

37a су Угаах, Угаагдах,
Угаалга.

38a Ег. 25:1–9; 33:7.
су Асар.

б су Ариун Сүм, Их
Эзэний Өргөө.

39a Ег. 29:7.

су Томилох.

б су Ёслолууд—
Бусдын өмнөөс
үйлдэх ёслол.

в С ба Г 88:117.

г С ба Г 13:1;

84:31; 128:24;
ИС—Г 1:69.

д Езек. 41:4;

С ба Г 45:32; 87:8;
101:22.

төлөөх дүрмүүд болон шүүлтүүд билээ.

40 Мөн үнэнээр би та нарт хэлж байна, бибээр өөрийн ёслолуудыг энд өөрийн хүмүүст илчилж болохын тулд, энэ өргөө миний нэрэнд баригдаг;

41 Учир нь дэлхийн сууринаас өмнө “нуугдмал байсан зүйлүүдийг, цаг хугацааны бүрэн байдлын эрин үед хамаарах зүйлүүдийг өөрийн хүмүүст “илчлэхийн тулд би зохих ёсоор авч үзнэ.

42 Мөн энэ өргөөнд хамаарах бүх зүйлийг, мөн үүний санваарыг, мөн энэ нь дээр нь баригдах ёстой тэрхүү газрыг “би өөрийн үйлчлэгч Иосеф Смитэд үзүүлэх болно.

43 Мөн та нар үүнийг барихаар төлөвлөсөн тэрхүү газар дээр барих ёстой, учир нь тэр бол үүнийг барихаар та нарт миний сонгож авсан тэрхүү газар бөлгөө.

44 Хэрэв та нар өөрсдийн бүхий л хүчин чадлаар хөдөлмөрлөх аваас, тэрхүү хэсэг газрыг “ариун болгогдохоор би ариулан адислах болно.

45 Мөн хэрэв миний хүмүүс миний дуу хоолойг мөн өөрийн хүмүүсийг удирдахаар миний томилсон “үйлчлэгчдийн минь дуу хоолойг анхаарах аваас, болгоогтун, үнэнээр би та нарт хэлж байна, тэд байрнаасаа хөдөлгөгдөх нь үгүй.

46 Харин хэрэв тэд миний дуу хоолойг, мөн миний томилсон тэдгээр эрчүүдийн дуу хоолойг үл анхаарах аваас, тэд адислагдах нь үгүй, учир нь тэд миний ариун газруудыг, мөн миний ариун ёслолуудыг, мөн дүрмүүдийг, мөн тэдэнд миний өгдөг ариун үгсийг бохирлодог билээ.

47 Мөнхүү улиран тохиох дор хэрэв та нар миний нэрэнд өргөө барьж, мөн миний хэлэх зүйлүүдийг үл хийх аваас, би та нарт өгсөн “тангаргаа гүйцэтгэх нь үгүй, мөн миний гараас та нарын хүлээдэг амлалтуудыг ч гүйцэлдүүлэх нь үгүй хэмээн Их Эзэн хэлэв.

48 Учир нь адислалуудын “оронд, тийм ээ, өөрсдийн ажлуудаар та нар зүхлүүд, хилэгнэл, зэвүүцлийг, мөн шүүлтүүдийг толгой дээрээ, та нар миний өмнө үйлддэг өөрсдийн мунхаглалаар, өөрсдийн жигшүүрт хэргүүдээр авчирдаг хэмээн Их Эзэн хэлэв.

49 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлж байна, миний нэрэнд ажил хийлгэхээр хүмүүний үрсийн хэнд нь ч би зарлиг өгөхөд, мөн хүмүүний тэдгээр үрс өөрсдийн бүхий л хүчин чадалтайгаар мөн тэдэнд байгаа бүхэнтэйгээр одож, мөн “хичээл зүтгэлээ үл орхин уг ажлыг

41a С ба Г 121:26–32.

б Ефес 1:9–10;

С ба Г 27:13; 112:30.

в ИТ 1:9.

42a С ба Г 95:14–17.

44a су Ариун.

45a С ба Г 1:38.

су Бошиглогч.

47a су Тангараг.

48a Дэд хууль 28:15.

49a су Хичээл зүтгэл.

гүйцэтгэхэд, мөн дайснууд нь тэдэн дээр ирж мөн уг ажлыг гүйцэтгэхэд нь тэдэнд саад учруулах үед, болгоогтун, хүмүүний тэдгээр үрсийн гараас уг ажлыг цаашид үл ^бшаардан, харин өргөлүүдийг нь хүлээн авах нь миний хүсэл зориг болой.

50 Мөн миний ажилд саад учруулсан тэдний толгой дээр, тэд хэдийчинээ удтал үл “наманчилбал мөн намайг үзэн ядвал бибээр өөрийнхөө ариун хуулиуд болон зарлигуудыг зөрчил хийгээд алдсаар гурав дахь мөн дөрөв дэх ^бүеүдэд нь “айлчлах болно хэмээн Их Эзэн хэллээ.

51 Тиймийн тул, энэхүү шалтгааны учир дайснууд нь саад учруулсан Миссурийн “Жаксон гүнлэгт миний нэрэнд, хот мөн ^бөргөө барихаар бибээр зарлигласан тэдний өргөлүүдийг би хүлээж авсан билээ хэмээн Их Эзэн, та нарын Бурхан хэлж байна.

52 Мөн тэд хэдийчинээ удаан үл наманчилж, мөн намайг үзэн ядна, би тэдний толгой дээр гурав дахь мөн дөрөв дэх үеийнхэнд нь тохиох “шүүлт, хилэгнэл, мөн зэвүүцэл, гаслан, мөн сэтгэлийн шаналал, мөн шүд хавиралтаар хариулах болно хэмээн Их Эзэн, та нарын Бурхан хэлж байна.

53 Мөн уг ажлыг хийхээр зарлиг болгогдсон мөн дайснуудынхаа гараар, мөн доромжлолоор саад учруулагдсан тэд бүгдийн талаарх та нарын тайвшралын тулд үүнийг би та нарт жишээ болголоо хэмээн Их Эзэн, та нарын Бурхан хэлж байна.

54 Учир нь бибээр Их Эзэн, та нарын Бурхан билээ, мөн зүрх сэтгэлдээ “цэвэр ариун байгаа, мөн Миссурийн нутагт ^балагдсан та нарын ах дүүс тэд бүгдийг аврах болно хэмээн Их Эзэн хэлж байна.

55 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, та нарт миний зарлигласан юу ч байлаа бүх зүйлд та нар итгэлтэй байгаагаа өөрсдөө надад “нотлон харуулж болохын тулд, мөн би та нарыг адисалж, мөн алдар хүндэтгэл, үхэшгүй байдал болон мөнх амьдралыг та нарт титэмлэж болохын тулд миний нэрэнд, бүр энэ газарт ^бөргөө барихыг би та нарт дахин зарлиглаж байна.

56 Гаднын хүмүүсийг байрлуулахын тулд барихаар та нарт миний зарлигласан байрлах “байрны минь талаар эдүгээ би та нарт хэлье, энэ нь миний нэрэнд баригдаг, мөн миний нэр үүн дээр нэрлэгдэг, мөн миний үйлчлэгч

49б С ба Г 56:4; 137:9.

50а су Наманчлах,
Наманчлал.

б Дэд хууль 5:9;

с ба Г 98:46–47.

в Мозая 12:1.

51а су Жаксон гүнлэг,
Миссури (АНУ).

б С ба Г 115:11.

52а С ба Г 121:11–23.

54а су Цэвэр ариун,
Цэвэр ариун

байдал.

б С ба Г 98:13;

103:27–28.

55а Абр. 3:25.

б С ба Г 127:4.

56а С ба Г 124:22–24.

Иосеф болон түүний гэр бүл үеэс үед үүн дотор байрлаг.

57 Учир нь түүний тэргүүн дээр миний тавьсан томилолт, түүний тэрхүү адислал дараах үр удмынх нь тэргүүн дээр тэрчлэн тавигдах болно;

58 Мөн дэлхийн ястнуудын талаар би “Абрахамд хэлсэнчлэн, бүр үүнийг би өөрийн үйлчлэгч Иосефт хэлж байна: Чамаар мөн чиний ⁶үр удмаар дамжин дэлхийн ястнууд адислагдах болно.

59 Тиймийн тул, миний үйлчлэгч Иосеф болон түүний дараах үр удам нь үеэс үед үүрд мөн мөнхөд тэр байранд байртай байг хэмээн Их Эзэн хэлж байна.

60 Мөн тэр байрны нэр нь Наувугийн Байр хэмээн дуудагдаг; мөн энэ нь амьдрахад хүмүүнд баяртай байг, мөн тэрээр Сионы алдар сууг, мөн үүний алдар сууг, үүний суурийн чулууг бясалган бодож болохын тулд ядарсан аянчинд алжаалаа тайлах газар байг;

61 Алдарт “ургамлууд, мөн үүний ханануудын дээрх ⁶харуулууд байхаар миний тавьсан тэднээс тэрчлэн тэрээр зөвлөгөө хүлээн авч болохын тулд буюу.

62 Болгоогтун, үнэнээр би та нарт хэлье, миний үйлчлэгч Жорж Миллер, мөн миний үйлчлэгч Лайман Вайт, мөн миний үйлчлэгч Жон Снайдер, мөн миний үйлчлэгч

Петр Хоос нар, өөрсдийгөө зохион байгуулаг, мөн тэднээс, нэгийг нь тэр байр барих зорилгын төлөө чуулгынхаа ерөнхийлөгч байхаар томилог.

63 Мөн тэд дүрмийг бий болгох ёстой, үүгээр тэд уг байшинг барих хувьцаа хүлээн авч болно.

64 Мөн тэд уг байранд нэгж хувьцааны төлөө тавин доллараас багыг хүлээн авах ёсгүй, мөн уг байранд хувьцааны төлөө хэнээс ч гэсэн арван таван мянган доллар хүлээн авах нь тэдэнд зөвшөөрөгдөх ёстой.

65 Харин хэнээс ч гэсэн арван таван мянган доллараас илүү хувьцаа хүлээн авах нь тэдэнд зөвшөөрөгдөх ёсгүй.

66 Мөн уг байранд хэнээс ч гэсэн тавин доллараас доош нэгж хувьцаа хүлээн авах нь тэдэнд зөвшөөрөгдөх ёсгүй.

67 Мөн хувьцаагаа хүлээн авсан үедээ хувьцаагаа тэдний гарт төлөхөөс бусдаар хувьцаа эзэмшигчийнх нь хувиар аль ч хүнийг энэ байранд хүлээн авах нь тэдэнд зөвшөөрөгдөх ёсгүй;

68 Мөн тэдний гарт төлсөн хувьцааны тоо хэмжээгээр уг байранд хувьцааг тэр хүлээж авах ёстой; харин хэрэв тэрээр тэдний гарт юу ч төлөөгүй бол тэрээр уг байрны ямар ч хувьцааг хүлээн авах ёсгүй.

69 Мөн хэрэв хэн нэгэн нь

58a Эхл. 12:3; 22:18;
Абр. 2:11.
су Абрахам.

б С ба Г 110:12.
су Абрахамын
гэрээ.

61a Иса. 61:3;
Езек. 34:29.
б су Харах, Харуул.

тэдний гарт хувьцаа төлсөн бол энэ нь уг байран дахь, өөрийнх нь, мөн түүний дараах үеийнхэнд нь үеэс үед, тэдний хувьцаа байх болно, тэр болон түүний өв залгамжлагчид урт хугацаагаар уг хувьцааг эзэмших болно, мөн хэрэв та нар миний тааллыг хэрэгжүүлэх аваас, хувьцааг тэдний өөрсдийнх нь сайн дурын хүсэл хийгээд үйлдлээр тэдний гараас зарах буюу шилжүүлэх ёсгүй хэмээн Их Эзэн, та нарын Бурхан хэлж байна.

70 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, хэрэв миний үйлчлэгч Жорж Миллер, мөн миний үйлчлэгч Лайман Вайт, мөн миний үйлчлэгч Жон Снайдер, мөн миний үйлчлэгч Петр Хоос нар аливаа хувьцааг мөнгөөр, эсвээс өмч хөрөнгийг тэд хүлээн авахдаа мөнгөн үнэлгээгээр хүлээн авах бөгөөс, тэд тэрхүү хувьцааны ямар ч хэсгийг гагцхүү тэр байрнаас өөр аливаа зорилгоор ашиглах ёсгүй.

71 Мөн хэрэв тэд уг хувьцааны ямар нэг хэсгийг тэрхүү байрнаас өөр газарт хувьцаа эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж, мөн гагцхүү уг байрнаас өөр хаа нэгтээ өөр газар ашигласан тэр хувьцааны төлөө дөрөв нугалж буцаан төлөөгүй бол тэд зүхэгдэх болно, мөн байрнаасаа шилжүүлэгдэн авагдах болно хэмээн Их Эзэн Бурхан

хэлж байна, учир нь Их Эзэн би бол Бурхан мөн эдгээр зүйлүүдийн юугаар ч “шогуулж чадахгүй.

72 Үнэнээр, би та нарт хэлж байна, миний үйлчлэгч Иосеф уг байрны барилгын тулд, түүнд сайн санагдсанаар тэдний гарт хувьцааг төлөг; харин миний үйлчлэгч тэр байранд арван таван мянган доллараас илүүг, мөн тавин доллараас багыг төлж болохгүй; мөн өөр бусад хэн ч гэсэн адил хэмээн Их Эзэн хэлж байна.

73 Мөн өөрсдийнхөө талаарх миний тааллыг мэдэхийг хүсдэг бусад нь буй, учир нь тэд үүнийг миний гараас асуусан билээ.

74 Тиймийн тул, би өөрийн үйлчлэгч Винсон Найтын талаар та нарт хэлнэ, хэрэв тэрээр миний тааллыг хэрэгжүүлэх аваас, хөрөнгийг өөрийнхөө тулд, мөн өөрийнхөө дараах үеийнхэндээ үеэс үед уг байранд тавиг.

75 Мөн ядуус болон гачигдагсдын учир “гуйхын тулд тэрээр хүмүүсийн дунд дуу хоолойгоо удаан хийгээд чангаар өргөг; мөн тэрээр бүтэлгүйтэхгүй байг, мөн зүрх сэтгэл нь унахгүй байг; мөн бибээр түүний ⁶өргөлүүдээс хүлээж авах болно, учир нь тэд надад Каины өргөлүүдийн адил байх нь үгүй, учир нь тэрбээр минийх билээ хэмээн Их Эзэн хэлж байна.

76 Түүний гэр бүл баясч мөн

зүрх сэтгэлээ зовлон зүдгүүрээс холдуулаг; учир нь би түүнийг сонгож мөн түүнийг тослон томилсон билээ, мөн тэрээр гэр бүлийнхээ дотор хүндлэгдэх болно, учир нь бибээр түүний бүх нүглийг өршөөх болно хэмээн Их Эзэн хэлж байна. Амен.

77 Үнэнээр би чамд хэлж байна, миний үйлчлэгч Хайрум өөрт нь сайн санагдсанаар хувьцааг өөрийнхөө тулд, мөн өөрийнхөө дараах үр удамдаа үеэс үед уг байранд тавиг.

78 Миний үйлчлэгч Исаак Галланд хувьцааг уг байранд тавиг; учир нь Их Эзэн бибээр тэр байрны дотор хийсэн ажлынх нь төлөө түүнийг хайрладаг билээ, бүх нүглийг нь өршөөх болно; тиймийн тулд, тэрээр уг байрны ашиг сонирхлын тулд үеэс үед дурсагдаг.

79 Миний үйлчлэгч Исаак Галланд та нарын дунд томилогдог, мөн миний үйлчлэгч Виллям Марксаар томилогдог, мөн түүнээс адислагдсан байж, миний үйлчлэгч Иосефын тэдэнд зааж өгөх ажлыг биелүүлэхийн тулд миний үйлчлэгч Хайрумтай хамт яваг, мөн тэд агуу ихээр адислагдах болно.

80 Миний үйлчлэгч Виллям Маркс өөрт нь сайн санагдсанаар тэр байранд хувьцааг өөрийнхөө болон үеэс үе дэх үр удмынхаа төлөө төлөг.

81 Миний үйлчлэгч Хенри

Г.Шервуд өөрт нь сайн санагдсанаар тэр байранд өөрийнхөө болон өөрийн дараах үеэс үе дэх үр удмынхаа төлөө хувьцааг төлөг.

82 Миний үйлчлэгч Виллям Лоо өөрийнхөө болон өөрийн дараах үеэс үе дэх үр удмын төлөө тэр байранд хувьцааг төлөг.

83 Хэрэв тэрээр миний тааллыг хэрэгжүүлэх аваас, тэрээр гэр бүлээ дорнод нутгууд уруу бүр Көртланд уруу бүү авч яваг; гэсэн хэдий ч Их Эзэн бибээр Көртландыг барих болно, харин үүний оршин суугчдын тулд цээрлүүлэлтийг Их Эзэн бибээр бэлтгэсэн билээ.

84 Мөн миний үйлчлэгч Алмон Баббитын хувьд миний таашаалд үл нийцэх олон зүйл буй; болгоогтун, тэрээр миний томилсон зөвлөхийн, бүр миний Сүмийн Тэргүүн Зөвлөлийн оронд өөрийн зөвлөлийг бий болгохыг санаархаж байна; мөн тэрээр миний хүмүүсийн шүтээний тулд “алтан тугал бий болгожээ.

85 Миний зарлигуудыг сахих явдлыг эрэлхийлэхээр энд ирсэн хүн энэ газраас бүү “яваг.

86 Хэрэв тэд энд амьдрах аваас тэд надад амьдраг; хэрэв тэд нас нөгчих аваас надад нас нөгчиг; учир нь тэд энд бүхий л хөдөлмөрүүдээсээ “амраг, мөн ажлуудаа үргэлжлүүлэг.

87 Тиймийн тул, миний

үйлчлэгч Виллям итгэл найдвараа надад тавиг, уг нутгийн өвчин эмгэгийн улмаас гэр бүлийнхээ талаар эмээхээ болиг. Хэрэв та нар намайг “хайрладаг аваас, зарлигуудыг минь сахигтун; мөн уг нутгийн өвчин эмгэг та нарын алдар сууд ⁶тус дөхөм үзүүлэх болно.

88 Миний үйлчлэгч Виллям явж мөн тэрбээр миний “Сүнсээр хөдөлгөгдөн, үүрдийн сайн мэдээг минь Варшавын оршин суугчдад, мөн тэрчлэн Картейжийн оршин суугчдад, мөн тэрчлэн Берлингтоны оршин суугчдад, мөн тэрчлэн Мадисоны оршин суугчдад чанга дуу хоолойгоор, мөн агуу баяслаар тунхаглаг, мөн миний ерөнхий чуулганы цаашдын заавруудыг тэвчээртэйгээр мөн хичээнгүйлэн хүлээг хэмээн Их Эзэн хэлж байна.

89 Хэрэв тэрээр миний тааллыг хэрэгжүүлэх аваас, тэрээр үүнээс хойш миний үйлчлэгч Иосефын зөвлөгөөг ядуусын “зорилгыг дэмжих сонирхолтойгоор анхаараг, мөн миний ариун үгийн ⁶шинэ орчуулгыг дэлхийн оршин суугчдад зориулан нийтлэг.

90 Мөн хэрэв тэрээр үүнийг хийх аваас, тэрээр орхигдох-

гүйн тулд, мөн түүний үр удам талх “гуйхгүйн тулд бибээр түүнийг үй олон адислалаар ⁶адислах болно.

91 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, адислалаар, мөн тэрчлэн эрхээр үүнд эцгээрээ томилогдсон миний үйлчлэгч Хайрум Санваартны болон “Патриархын албан тушаалыг авахын тулд миний үйлчлэгч Хайрумын оронд миний үйлчлэгч Виллям миний үйлчлэгч Иосефт зөвлөхөөр тохоогдон томилогдож, мөн тослогдог.

92 Үүнээс хойш тэрээр миний бүх хүмүүсийн тэргүүн дээрх “патриархын адислалуудын түлхүүрүүдийг атгахын тулд буюу,

93 Тэрээр хэнийг ч адислалаа гэсэн адислагдаж, мөн хэнийг ч “зүхлээ гэсэн зүхэгдэхийн тулд буюу; дэлхий дээр тэрээр юуг ч ⁶холбоолоо гэсэн тэнгэрт холбогдохын тулд; мөн тэрээр дэлхий дээр юуг ч цуцаллаа гэсэн тэнгэрт цуцлагдах болно.

94 Мөн энэ цагаас хойш миний үйлчлэгч Иосефын нэгэн адил тэрээр миний сүмд бошиглогч, мөн “үзмэрч, мөн илчлэгч байж болохын тулд би түүнийг томилж байна;

95 Мөн тэрээр тэрчлэн миний үйлчлэгч Иосефтой

87a Иохан 14:15.

б С ба Г 121:8; 122:7.

88a су Бурхан, Бурхан тэргүүтэн—Бурхан Ариун Сүнс.

89a С ба Г 78:3.

б ө.х. Библийн Иосеф Смитийн орчуулга.

90a Дуул. 37:25.

б су Адислах, Адислагдах, Адислал.

91a С ба Г 107:39–40.

су Патриарх, Патриархын.

92a су Патриархын

адислал.

93a С ба Г 132:45–47.

б Мат. 16:19.

су Лацдах, Лацдалт.

94a С ба Г 107:91–92.

су Үзмэрч.

эвсэн ажиллаж болохын тулд бөлгөө; мөн тэрээр асууж мөн хүлээн авч болох “түлхүүрүүдийг түүнд өөрт нь үзүүлэх миний үйлчлэгч Иосефын зөвлөгөөг тэрээр хүлээн авч мөн адислалаар, мөн алдар суугаар мөн алдар хүндэтгэл, бас санваар, мөн нэгэн цагт миний үйлчлэгч байсан ⁶Оливер Каудери, түүн дээр тавьсан тэрхүү санваарын бэлгүүдээр титэмлэгдэх болно;

96 Түүний нэр үеэс үед, үүрд мөн мөнхөд хүндэтгэлийн дурсамжид байхын тулд түүнд миний үзүүлэх зүйлүүдийн тухай миний үйлчлэгч Хайрум гэрчилж болохын тулд буюу.

97 Миний үйлчлэгч Виллям Лоо, тэрээр адислалуудыг асууж мөн хүлээн авах түлхүүрүүдийг тэрчлэн хүлээн аваг; тэрээр миний өмнө “даруу байг, мөн ⁶заль мэхгүй байг, мөн тэрээр миний Сүнснийг, бүр мөн бүх зүйлийн үнэнийг түүнд үзүүлэх мөн юу хэлэхийг нь яг цагт нь түүнд өгөх ⁶Тайтгаруулагчийг тэрээр хүлээн авах болно.

98 Мөн эдгээр “тэмдгүүд түүнийг дагалдах болно — тэрээр өвчтөнүүдийг ⁶эдгээх болно, тэрээр чөтгөрүүдийг зайлуулах болно, мөн өөрт нь үхлийн хор өгөх тэднээс чөлөөлөгдөх болно;

99 Мөн “хорт могой түүний өсгийг хатгаж үл чадах зөрөг дээр тэрбээр удирдагдах болно, мөн тэрээр бодол санааныхаа ⁶төсөөлөлд бүргэдийн далавчин дээр мацах лугаа адил байх болно.

100 Мөн хэрэв тэрээр нас барагсдыг босгох ёстой хэмээн би хүсэх аваас, тэрээр дуу хоолойгоо бүү буцааг.

101 Тиймийн тул, миний үйлчлэгч Виллям баяр хөөрхийгээд баясалтайгаар, мөн хаан сэнтий дээрээ үүрд мөн мөнхөд залран буй түүнд хосаннаатайгаар чанга хашгирч мөн бүү эмээг хэмээн Их Эзэн, та нарын Бурхан хэлж байна.

102 Болгоогтун, би та нарт хэлж байна, миний үйлчлэгч Виллям мөн миний үйлчлэгч Хайрум, мөн тэдэнд хоёулханд нь зориулсан үүрэг даалгавар надад нөөцөд буй; мөн миний үйлчлэгч Иосеф гэртээ үлдэг, учир нь тэрээр хэрэгтэй байгаа билээ. Үлдсэнийг нь бибээр та нарт үүнээс хойш үзүүлэх болно. Бүр тийм буюу. Амен.

103 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, хэрэв миний үйлчлэгч “Сидней надад үйлчилж мөн миний үйлчлэгч Иосефт зөвлөх байх аваас, тэрээр өндийн босч мөн хүрч ирэн дуудлагынхаа албан тушаалд зогсон, мөн

95a С ба Г 6:28.

б су Оливер Каудери.

97a су Даруу, Даруу байдал.

б су Заль мэх.

в су Тайтгаруулагч.

98a Марк 16:17–18.

су Сүнсний бэлгүүд.

б су Эдгээх, Эдгэрэх.

99a С ба Г 84:71–73.

б Ег. 19:4; Иса. 40:31.

103a су Сидней Ригдон.

миний өмнө өөрийгөө даруусгаг.

104 Мөн хэрэв тэрээр хүлээн авч болохуйц өргөлийг мөн хүлээн зөвшөөрөлтүүдийг надад өргөж мөн миний хүмүүстэй хамт үлдэх аваас, болгоогтун, тэрээр эдгэрэхийн тулд Их Эзэн, та нарын Бурхан бибээр түүнийг эдгээх болно; мөн тэрээр уулс дээр дуу хоолойгоо дахин өргөж, мөн миний нүүрний өмнө “төлөөлөн яригч байх болно.

105 Тэрээр ирж мөн миний үйлчлэгч Иосеф Смитийн оршин сууж буй орчинд гэр бүлээ суурьшуулаг.

106 Мөн өөрийн бүх аялалд бүрэн дуу адилаар дуу хоолойгоо өргөж, мөн ирэх тэрхүү хилэгнэлээс зугтахыг дэлхийн оршин суугчдад сэрэмжлүүлэг.

107 Тэрээр миний үйлчлэгч Иосефт туслаг, мөн тэрчлэн миний үйлчлэгч Виллям Лоо дэлхийн хаадад чин сэтгэлээсээ “тунхаглахад, бүр өмнө нь би чамд хэлсэнчлэн миний үйлчлэгч Иосефт туслаг.

108 Хэрэв миний үйлчлэгч Сидней миний тааллыг хэрэгжүүлэх аваас, тэрээр гэр бүлээ “дорно нутгууд уруу бүү шилжүүлэг, харин тэрээр миний хэлсэнчлэн, оршин суух газраа өөрчлөг.

109 Болгоогтун, та нарт миний тогтоож өгсөн тэр хотоос,

бүр “Наувугийн хотоос гадна аюулгүй байдал хийгээд хоргодох газрыг олохоор тэрбээр эрэлхийлэх нь миний таалал биш.

110 Үнэнээр би та нарт хэлж байна, бүр эдүгээ, хэрэв тэрээр миний дуу хоолойг анхаарах аваас, энэ нь түүнд сайн байх болно. Бүр тийм буюу. Амен.

111 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, байрлах байр, бүр Наувугийн Байр барихаар миний томилсон тэдний гарт хувьцааг төлөг.

112 Хэрэв тэрээр сонирхолтой байх аваас тэрээр үүнийг хийг; мөн тэрээр миний үйлчлэгч Иосефын зөвлөгөөг анхаарч мөн тэрээр хүмүүний итгэл найдварыг хүлээж болохын тулд өөрийнхөө гараар хөдөлмөрлөг.

113 Мөн тэрээр өөрийнх нь анхаарал халамжид итгэл хүлээлгэн өгсөн бүх зүйлд бүр цөөн хэдхэн зүйлд итгэлтэйгээ нотлон харуулах ёстой, тийм ээ, тэрээр олны дээр “захирагч болгогдох болно;

114 Тиймийн тул, тэрээр өргөмжлөгдөхийн тулд өөрийгөө “доош тавиг. Бүр тийм буюу. Амен.

115 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, хэрэв миний үйлчлэгч Роберт Д.Фостер дуу хоолойг минь дуулгавартай дагах аваас, хаалга нь цагаас цагт түүнд

104a Ег. 4:14–16;
2 Ниф. 3:17–18;
С ба Г 100:9–11.
107a С ба Г 124:2–4.

108a С ба Г 124:82–83.
109a су Науву,
Иллиной (АНУ).
113a Мат. 25:14–30.

114a Мат. 23:12;
С ба Г 101:42.

нээлттэй байхын хэрээр тэрээр түүнтэй хийсэн гэрээнийхээ дагуу, миний үйлчлэгч Иосефт зориулж байр бариг.

116 Мөн тэрээр өөрийн бүхий л мунхаглалуудаас наманчилж, мөн өөрийгөө “энэрлээр хувцаслаг; мөн хилэнцтийг үйлдэхээ болиг, бүх хахир хатуу үг яриагаа хажуу тийш тавиг;

117 Мөн тэрчлэн хувьцааг өөрийнхөө төлөө, мөн өөрийн дараах үеэс үе дэх үр удмынхаа төлөө Наувугийн Байрны чуулгын гарт төлөгтүн;

118 Мөн миний үйлчлэгчид Иосеф, мөн Хайрум, мөн Виллям Лоо, мөн Сионы суурийг тавихаар миний дуудсан эрх баригчдын зөвлөгөөг анхаарагтун; мөн энэ нь түүнд үүрд болон мөнхөд сайн байх бөлгөө. Бүр тийм буюу. Амен.

119 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, хэрэв тэрээр Мормоны Номонд, мөн та нарт миний өгсөн илчлэлтүүдэд үл итгэгч байх аваас, ямар ч хүн Наувугийн Байрны чуулгад хувьцаа бүү төлөг хэмээн Их Эзэн та нарын Бурхан хэлж байна.

120 Учир нь үүнээс “илүү буюу дутуу нь хилэнцтээс ирдэг, мөн адислалуудаар бус, харин зүхлүүдээр айлч-

лагддаг байх болно хэмээн Их Эзэн, та нарын Бурхан хэлж байна. Бүр тийм буюу. Амен.

121 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, Наувугийн Байрыг барихад өөрсдийн хийсэн бүх хөдөлмөрийн төлөө нөхөн төлбөрийн шударга цалинг Наувугийн Байрны чуулга аваг; мөн тэдний цалин хөлс өөрсдийнх нь дунд тохиролцсоноор үүний үнэнд хамаатайн дагуу байг.

122 Мөн хувьцаа төлдөг хүн болгон хэрэв энэ нь тэднийг тэтгэхэд шаардагдах аваас цалингийнхаа өөрт ноогдох хувийг аваг хэмээн Их Эзэн хэлж байна; эс бөгөөс тэдний хөдөлмөрүүд тэр байран дахь хувьцаа болж тэдэнд тооцогдох ёстой. Бүр тийм буюу. Амен.

123 Үнэнээр би та нарт хэлж байна, та нар үүнийг, бүр миний Төрсөн Ганц Хүүгийн дэг жаягаарх “Мелкизедкийн дэг жаягийн дагуух санваарын ^бтүлхүүрүүдийг атгаж болохын тулд миний санваарт харьяалагддаг “албан тушаалуудыг эдүгээ би та нарт өгье.

124 Эхлээд, “патриарх байж миний сүмийн адислалуудын тулд, бүр та нар өөрсөд дээрээ ирж болох уруу таталтын тэрхүү ^бцагт та нар унахгүй байж болохын тулд гэтэлгэлийн өдөрт та нар ^блацдагдах

116a Кол. 3:14.
су Энэрэл.

120a Мат. 5:37;
С ба Г 98:7.

123a су Мелкизедек

санваар.
б су Санваарын
түлхүүрүүд.
в су Албан тушаал,
Албан

тушаалтан.
124a су Патриарх,
Патриархын.
б Илч. 3:10.
в Ефес 4:30.

амлалтын Ариун Сүнсний
лацдалтын адислалыг атга-
хын тулд Хайрум Смитийг
би та нарт өгье.

125 Миний бүх сүмийн дээр
тэргүүлэх ахлагч байхаар,
орчуулагч, илчлэгч, “үзмэрч,
мөн бошиглогч байхаар
өөрийн үйлчлэгч Иосефыг
би та нарт өгье.

126 Чуулга болон Тэргүүн
Зөвлөлийг бий болгож, нийт
сүмийн хувьд “бошиглолуудыг
хүлээн авч болохын тулд,
би өөрийн үйлчлэгч Сидней
Ригдон мөн өөрийн үйлчлэгч
Виллям Лоо хоёрыг түүнд
зөвлөхүүд байхаар өгч байна.

127 Аялагч Арванхоёрын
зөвлөлийн дээр ерөнхийлөгч
байх өөрийн үйлчлэгч “Бри-
гам Янгийг би та нарт өгч
байна.

128 Уг “Арванхоёр дэлхийн
дөрвөн хязгаарт миний хаант
улсын эрх мэдлийг нээх, мөн
үүний дараа хүн болгонд
миний үгийг илгээх түлхүү-
рүүдийг атгадаг бөлгөө.

129 Тэд бол Хебер С.Ким-
балл, Парлей П.Пратт,
Оорсон Пратт, Оорсон Хайд,
Виллям Смит, Жон Тейлор,
Жон Е.Пейж, Вилфорд
Вудрафф, Виллард Ричардс,
Жорж А.Смит нар болой;

130 “Давид Паттеныг би өөр-
төө авсан билээ; болгоогтун,
санваарыг нь түүнээс авах

хүн гэж үгүй бөлгөө, гэвч,
үнэнээр би та нарт хэлье,
мөн уг дуудлагад өөр нэгэн
томилогдож болно.

131 Мөн дахин, би та нарт
хэлье, Сионы суурийн чулуу-
ны тулд би та нарт “дээд
зөвлөлийг өгч байна—

132 Нэрлэвэл, Самуэл Бент,
Хенри Г.Шервуд, Жорж
Б.Харрис, Чарлес К.Рич, Томас
Гровер, Ньюел Найт, Давид
Дорт, Данбар Вилсон—Шей-
моур Брансоныг би өөртөө
авсан бөлгөө; түүний санваа-
рыг авах хүн гэж үгүй, гэвч
түүний оронд мөн уг сан-
ваарт өөр нэгэн томилогдож
болно; мөн үнэнээр би та
нарт хэлж байна, миний
үйлчлэгч Аарон Жонсон түү-
ний оронд энэ дуудлагад
томилогдог—Давид Фулл-
мер, Алфеус Катлер, Виллям
Хантингтон.

133 Мөн дахин, дээд сан-
ваартнуудын чуулга дээр
ерөнхийлөгч байхаар Дон
К.Смитийг би та нарт өгч
байна;

134 Алс холд тараагдсан
өөр өөр “гадаснуудад ажил-
лагч ерөнхийлөгчид буюу
үйлчлэгчдээр томилогдох
тэднийг тохирох болгох зор-
рилгын тулд тэрхүү ёслол
бий болгогдсон бөлгөө;

135 Мөн байнгын ерөнхий-
лөгчид байхаар томилогдо-

124₂ С ба Г 76:53; 88:3–4.

су Амлалтын
Ариун Сүнс.
д су Лацдах,
Лацдалт.

125_a С ба Г 21:1.

су Үзмэрч.

126_a С ба Г 90:4–5.

127_a су Бригам Янг.

128_a су Төлөөлөгч.

б Марк 16:15.

130_a су Давид

В.Паттен.

б С ба Г 124:19.

131_a су Дээд зөвлөл.

134_a су Гадас.

хоос бусдаар, хэрэв тэд сонгох аваас тэд тэрчлэн аялж болох бөлгөө; энэ нь тэдний дуудлагын албан тушаал мөн хэмээн Их Эзэн, та нарын Бурхан хэлж байна.

136 Тэд миний сүмийн Дээд санваартнуудын чуулгыг тэргүүлэхийн тулд Амаза Лайман мөн Ноа Пакард нарыг зөвлөхүүд байхаар би түүнд өгч байна хэмээн Их Эзэн хэлж байна.

137 Мөн дахин, би та нарт хэлж байна, санваар нь “ахлагч нарын чуулгын дээр тэргүүлдэг Жон А.Хикс, Самуел Виллямс, мөн Жессе Бейкер нарыг би та нарт өгье, уг чуулга нь байнгын тохиноулагчдын тулд байгуулагддаг бөлгөө; тэд аялж болох хэдий ч, харин тэд миний сүмд байнгын тохиноулагчид байхаар томилогддог болой хэмээн Их Эзэн хэлж байна.

138 Мөн дахин, “далын чуулгын дээр тэргүүлэхээр Жозеф Янг, Жозая Баттерфиелд, Даниел Майлес, Хенри Херриман, Зера Пулсифер, Левай Ханкок, Жеймс Фостер нарыг би та нарт өгье;

139 Уг чуулга нь аялагч дээд зөвлөл, миний төлөөлөгчид миний өмнө замыг бэлтгэхээр тэднийг хааш нь ч илгээлээ гэсэн бүх дэлхийд миний нэрийг гэрчлэх аялагч ахлагчдын төлөө үндэслэн байгуулагддаг болой.

140 Энэхүү чуулга хийгээд

ахлагч нарын чуулгын хоорондын ялгаа нь гэвэл, нэг нь байнга аялж, нөгөө нь цагаас цагт сүмүүдийн дээр тэргүүлэх нь болой; цагаас цагт тэргүүлэх үүргийг нэг нь хүлээдэг байхад мөн нөгөө нэг нь тэргүүлэх үүргийг хүлээдэггүй хэмээн Их Эзэн, та нарын Бурхан хэлж байна.

141 Мөн дахин, би та нарт хэлье, Винсон Найт, Самуел Х.Смит, мөн Шадрак Роундыг, хэрэв тэрээр “бишопын зөвлөлийн дээр тэргүүлэхийг хүлээн авбал, би та нарт өгье; дурдсан бишопын зөвлөлийн тухай мэдлэг нь чамд “Сургаал ба Гэрээ номонд өгөгдөх болно.

142 Мөн дахин, би та нарт хэлье, Самуел Рольф болон санваартнууд хариуцсан түүний зөвлөхүүд мөн багш нарын ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүд мөн тэрчлэн диконуудын ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүд мөн тэрчлэн гадасны ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүдийг болой.

143 Дээрх албан тушаалуудыг, мөн тэдгээрийн түлхүүрүүдийг, туслахын тулд мөн удирдахын тулд, тохиноуллын хийгээд миний гэгээнтнүүдийг “төгөлдөржүүлэх ажлын тулд би та нарт өглөө.

144 Мөн та нар эдгээр бүх албан тушаалыг дүүргэж мөн миний дурдсан тэдгээр нэрсийг миний ерөнхий чуулган

137a С ба Г 107:11–12,
89–90.
су Ахлагч; Чуулга.

138a су Дал.
141a С ба Г 68:14; 107:15.
б су Сургаал ба

Гэрээ.
143a Ефес 4:11–14.

дээр та нар “зөвшөөрөх, эсвээс тэдгээрийг зөвшөөрөх ёсгүй хэмээх зарлигийг би та нарт өгч байна.

145 Мөн та нар миний нэрэнд үүнийг барьсан үедээ

миний байранд эдгээр бүх албан тушаалын тулд өрөөнүүдийг бэлтгэх ёстой хэмээн та нарын Их Эзэн, Бурхан хэлж байна. Бүр тийм буюу. Амен.

ХЭСЭГ 125

1841 оны гуравдугаар сард Иллинойн Наувуд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Айовагийн нутаг дэвсгэр дэх Гэгээнтнүүдийн талаар өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 4: 311–312).

1–4, Гэгээнтнүүд хотууд барьж мөн Сионы гадаснуудад цугларах ёстой.

АЙОВАГИЙН нутаг дэвсгэр дэх гэгээнтнүүдийн талаарх Их Эзэний таалал юу вэ?

2 Үнэнээр, Их Эзэн бибээрийн та нарт хэлж байна, хэрэв миний нэрээр өөрсдийгөө “нэрлэдэг мөн миний гэгээнтнүүд болохыг чармайдаг тэд миний тааллыг хэрэгжүүлж мөн тэдний талаарх зарлигуудыг минь сахих аваас, тэд ирэх цагийн тулд нөөцөд байх тэр зүйлийн төлөө бэлтгэгдэж болохын тулд, бибээр

өөрийн үйлчлэгч Иосефоор тэдэнд томилох тэр газруудад тэд өөрсдийгөө цуглуулж мөн миний нэрэнд хотуудыг байгуулаг.

3 Наувугийн хотын эсрэг талын газар дээр тэд миний нэрэнд хот байгуулаг, мөн “Зарахемла нэр үүн дээр нэрлэгдэг.

4 Мөн дорнодоос, мөн өрнөдөөс, мөн умардаас мөн өмнөдөөс ирэх, тэнд амьдрах хүсэлтэй тэд бүгд, “Нашвилл хот, эсвээс Науву хотод, мөн миний тогтоож өгсөн бүх гадаснуудад байдагтай адил өвийг мөн тэнд аваг хэмээн Их Эзэн хэлж байна.

ХЭСЭГ 126

1841 оны долдугаар сарын 9-нд Иллинойн Наувуд Бригам Янгийн гэрт Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 4:382). Энэ үед Бригам Янг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч байв.

144a С ба Г 26:2.
су Нийтийн
дэмжлэг.

125 2a су Есүс Христ—

Өөрсөд дээрээ
Есүс Христийн
нэрийг авах.

3a су Зарахемла.

4a ө.х. Айовагийн
Лий гүнлэг дэх
Нашвилл.

б су Гадас.

1–3, Бригам Янг хөдөлмөрүүдийнхээ учир сайшаагдаж мөн ирээдүйн гадаад дахь аяллаас чөлөөлөгдөв.

ЭРХЭМ хүндэт мөн нэн хайрт ах, “Бригам Янг, үнэнээр Их Эзэн танд ийн хэлж байна, Миний үйлчлэгч Бригам, өнгөрсөн үеүдтэй адилаар гэр бүлээ орхих нь чиний гараас дахин шаардагдахгүй, учир нь чиний

өргөл надад хүлээн авагдахуйц билээ.

2 Мөн миний нэрийн төлөөх чиний аяллууд дахь чиний “хөдөлмөр хийгээд хүнд ажлыг чинь би харсан бөлгөө.

3 Миний үгийг холд илгээж мөн энэ үеэс хойшид мөн үүрд “гэр бүлдээ онцгой халамж тавихыг тиймийн тул би чамд зарлиглаж байна. Амен.

ХЭСЭГ 127

1842 оны есдүгээр сарын 1-нээр Наувуд хаяглагдсан нас барагсдын өмнөөс хийлгэх баптисмын талаарх удирдамжуудыг агуулсан Бошиглогч Иосеф Смитээс Иллинойн Науву дахь Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд хандсан захидал оршвой (History of the Church, 5:142–144).

1–4, Иосеф Смит мөрдлөг хавчлага хийгээд гай зовлонд алдаршина; 5–12, Нас барагсдын төлөөх баптисмд холбогдолтой үздгүүд хадгалагдах ёстой.

ИХ ЭЗЭН надад илчилсэнчлэн, миний дайснууд Миссурид мөн энэ Муж улсад аль алинд нь намайг дахин мөрдөн мөшгиж байлаа: мөн тэд намайг “шалтгаангүйгээр мөшгихийн улмаас, миний эсрэг тэдний өдөөж буй явууллагууд тэдний хувьд шударга ёс буюу эрхийн өчүүхэн төдий сүүдэр буюу өнгөгүй байна; мөн тэдний санаархлууд хамгийн хар бараан өнгөтэй худал хуурмагийн, миний өөрийн

аюулгүй байдал мөн энэ хүмүүсийн аюулгүй байдлын төлөө энэ газрыг түр хугацаагаар орхих нь миний хувьд мэргэн ухаан бөгөөд ингэх шаардлагатай хэмээн би бодох боллоо. Бүх ажлыг шуурхай хийгээд зохих ёсоор нь явуулах төлөөний хүмүүс хийгээд бичиг хэргийн ажилтнуудад би ажил хэргүүдээ орхин явлаа, мөн өмч хөрөнгийг зарах замаар, эс бөгөөс тухайн хэрэг явдал шаардаж болохын хэрээр эсвээс нөхцөл байдал үүнд боломж олгохын хэрээр миний бүх өр төлбөр тогтоосон цагт цуцлагдахад санаа тавих болно хэмээн ажлын холбоотой бүх хүмүүст би хэлэхийг

126 1а су Бригам Янг.
2а су Ажлууд.

3а су Гэр бүл.
127 1а Иов 2:3;

Мат. 5:10–12;
1 Петр 2:20–23.

хүсч байна. Бибээр шуурга бүрмөсөн шуураад өнгөрснийг мэдээд, тэгээд би та нар дээр эргэн ирэх болно.

2 Мөн миний туулахаар дуудагдсан “зовлон зүдгүүрүүдийн хувьд тэдгээр нь хүмүүний ⁶атаа жөтөө хийгээд хилэгнэл амьдралын минь бүх өдрүүдэд миний нийтлэг хувь заяа байсан болохоор надад өчүүхэн зүйл мэт санагдана, хэрэв би дэлхийн сууринаас өмнөх үеэс нэгэн сайн төгсгөлийн тулд эсвээс та нар үүнийг муу хэмээн үзэж болох тэр зүйлд ⁶томилогдоогүй бол, үүний шалтгаан нь ойлгомжгүй мэт санагдах болно. Та нар өөрсдийнхөөрөө шүүгтүн. Энэ нь сайн, эсвээс муу байлаа ч Бурхан бүх зүйлийг мэддэг бөлгөө. Гэсэн хэдий ч, гүнзгий ус бол дотор нь миний сэлж дассан зүйл. Энэ бүгд миний хувьд ердийн мөн чанар болжээ; мөн, бибээр ⁷гай зовлондоо Паулын адил бахархмаар санагдана; энэ өдрийг хүртэл миний эцгүүдийн Бурхан тэдгээр бүгдээс намайг чөлөөлсөн бөлгөө, мөн намайг энэ цагаас хойш чөлөөлөх болно; учрыг болгоогтун, мөн харатун, би бүх дайснаа ялах болно, учир

нь Их Эзэн Бурхан үүнийг ярилаа.

3 Бүх гэгээнтнүүд баясаг, тиймийн тул, мөн үлэмж баярлаг; учир нь Израилын “Бурхан тэдний Бурхан болой, мөн тэрбээр тэдний бүх доромжлогчдын толгой дээрх хариу төлөөсний шударга шагналыг хэмжин тогтоох болно.

4 Мөн дахин, Их Эзэн үнэнээр ийн хэлнэ: Миний “ариун сүмийн ажил, мөн та нарт миний томилсон бүх ажил үргэлжлэг мөн бүү зогсог; мөн та нарын ⁶хичээл зүтгэл, мөн та нарын шаргуу тэвчээр, мөн тэсвэр өсөг, мөн та нар шагналаа дэмий алдах нь үгүй хэмээн Түмний Их Эзэн хэлж байна. Мөн хэрэв тэд та нарыг ⁶мөрдөн хавчих аваас тэд та нараас өмнө байсан бошиглогчид хийгээд зөв шударга хүмүүсийг тийн мөрдөн хавчиж байсан хэрэг. Энэ бүхний төлөө тэнгэрт шагнал буй.

5 Мөн дахин, та нарын “нас барагсдын төлөөх ⁶баптисмтай холбогдуулан би та нарт нэг үг хэлье.

6 Үнэнээр ийн Их Эзэн та нарын нас барагсдын талаар хэлж байна: та нарын хэн нэгэн нь нас барагсдынхаа төлөө “баптисм хүртэх үед,

2а Дуул. 23:1–6.

су Хавчих,
Хавчлага.

б су Атаархал.

в су Урьдчилсан
томилолт.

г 2 Кор. 6:4–5.

су Дайсан.

3а 3 Ниф. 11:12–14.

4а С ба Г 124:55.

б су Хичээл зүтгэл.

в су Хавчих,

Хавчлага.

5а су Нас барагсдын

аврал.

б су БAPTИСМ,

БAPTИСМ хүртээх—

Нас барагсдын
төлөөх баптисм.

6а 1 Кор. 15:29;

С ба Г 128:13, 18.

⁶цэдэг үйлдэгч байг, мөн тэрбээр та нарын баптисмуудын тухай нүдээр гэрчлэгч байг; тэрбээр үнэнээр гэрчилж болохын тулд чихээрээ тэр сонсог хэмээн Их Эзэн хэлж байна.

7 Та нарын бүх цэдэгт энэ нь тэнгэрт “цэдэглэгдэж болохын тулд буюу; та нар дэлхий дээр юуг ч ⁶холболоо гэсэн, тэнгэрт холбогдож болох бөлгөө; та нар дэлхийд юуг ч цуцаллаа гэсэн тэнгэрт цуцлагдаж болох бөлгөө;

8 Учир нь “санваарт хамаарах олон зүйлийг би ⁶сэргээх гэж байна хэмээн Түмний Их Эзэн хэлж байна.

9 Мөн дахин, бүх “цэдэг миний ариун сүмийн архивуудад тавигдан нэг үеэс нөгөө үеийнхэнд дурсамжид хадгалагдаж болохын тулд тэдгээр нь эмх цэгцэд байг хэмээн Их Эзэн хэлж байна.

10 Дараагийн Хүндэтгэлийн өдөр нас барагсдын төлөөх баптисмын сэдвээр индэр дээрээс тэдэнд хандахыг би-

бээр үлэмж агуу эрмэлзлээр хүсч байснаа би бүх гэгээнтнүүдэд хэлэх болно. Гэвч үүнийг хийх нь миний хүч чадлаас хэтэрсэн учраас, уг сэдвээр Их Эзэний үгийг, түүнчлэн бусад олон зүйлийг би цагаас цагт бичиж, мөн үүнийг мөн та нарт шуудангаар илгээж байх болно.

11 Эдүгээ илүү цаг байхгүйн улмаас би энэ захидлаа одоо төгсгөл болгоё; учир нь дайсан бэлэн байдалд байна, Аврагч хэлсэнчлэн, энэ дэлхийн “хунтайж ирэх болой, харин надад орших юу ч түүнд үгүй бөлгөө.

12 Болгоогтун, та нар бүгдээрээ аврагдах болтугай гэдэг нь Бурханд хандах миний залбирал бөлгөө. Мөн бибээр өөрийгөө Их Эзэн дэх та нарын үйлчлэгч, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн бошиглогч хийгээд “үзмэрч хэмээн тодорхойлно.

Иосеф Смит

ХЭСЭГ 128

1842 оны есдүгээр сарын 6-нд Иллинойн Наувуд, нас барагсдын төлөөх баптисмын талаарх цаашдын удирдамжуудыг агуулсан, Бошиглогч Иосеф Смитээс Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд хандсан захидал оршвой (History of the Church, 5:148–153).

<p>66 С ба Г 128:2–4, 7. 7а су Амьдралын Ном. б су Лацдах, Лацдалт.</p>	<p>8а су Мелкизедек санваар. б су Сайн мэдээний сэргээлт. 9а С ба Г 128:24.</p>	<p>11а Иохан 14:30; исо, Иохан 14:30. су Чөтгөр. 12а С ба Г 124:125. су Үзмэрч.</p>
---	---	---

1-5, Орон нутгийн хийгээд ерөнхий цэдэг үйлдэгчид нас барагсдын төлөөх баптисмуудын баримтыг нотлох ёстой; 6-9, Тэдний цэдгүүд хүчин төгөлдөр хийгээд дэлхий дээр мөн тэнгэрт цэдэглэгддэг болой; 10-14, Баптисмын сан нь булшийг бэлэгддэг бөлгөө; 15-17, Нас барагсдын төлөөх баптисмд холбогдох хүчийг Елиа сэргээв; 18-21, Өнгөрсөн эрин үеүдийн бүх түлхүүр, хүч, мөн эрх мэдлүүд сэргээгдэв; 22-25, Баярт мөн алдар суут мэдээ нь амьд байгаа хүмүүс хийгээд нас барагсдын төлөө тунхаглагддаг болой.

БИ байгаа газраа орхин явахаас өмнө захидалдаа өгүүлсэнчлэн, та нарт цагаас цагт бичиж, мөн олон асуудалд холбогдох мэдээллийг та нарт өгч, уг сэдэв миний оюун бодлыг эзэмдэж мөн миний бие дайснуудаараа мөрдөгдөн хавчигдсан цагаас хойш энэ нь бодол санааг минь нэн хүчтэйгээр эзэмдэхийн учир эдүгээ нас барагсдын төлөөх “баптисмын сэдвийг би нэгтгэн дүгнэж байна.

2 Цэдэг хөтлөгчийн талаарх илчлэлтийн тухай би та нарт цөөн үг бичсэн билээ. Энэ асуудалтай холбоо бүхий цөөн хэдэн нэмэлт санаа надад буйг би одоо нотлоё. Энэ нь Их Эзэний өмнө тэрээр үнэнээр цэдэг хөтлөгч байхын тулд нүдээр гэрчлэгч, мөн тэрчлэн чихээр сонсох “цэдэг хөтлөгч байх хэрэгтэй

нь миний өмнөх захидалд өгүүлэгдсэн билээ.

3 Эдүгээ, энэ асуудалтай холбогдон, бүх цагт ганцхан цэдэг хөтлөгч байх нь, мөн бүх ажил хэргийг гүйцэлдүүлэх нь түүний хувьд нэн хүнд байх буйза. Энэхүү хүндрэлээс зайлсхийхийн тулд, хотын хэсэг болгонд тэмдэглэлийг нямбайгаар хөтлөхөд сайн мэргэшсэн нэг цэдэг хөтлөгч томилогдох болно мөн тэрээр нүдээрээ үзэж, мөн чихээрээ сонссоныг өөрийн цэдэгт нотлон, он сар өдөр, мөн нэрс, мөн энэ мэтчилэн цааш нь мөн бүхий л үйлдлийн түүхийг бичиж, бүхэл дэг журмын зүйлүүдэд тус бүрд нь тухайлан мөн туйлын тодорхой байг, тэрчлэн хоёр буюу гурван “гэрчийн аманд үг бүр нь үндэслэгдэж болохын тулд, хэрэв тэнд хүмүүс байгаа бол, мөн үүнийг хэдийд ч нотлохоор дуудагдаж болох тэнд байгаа гурван өөр хувь хүнийг нэрлэг.

4 Тэгээд, эдгээр бусад цэдгүүд, тэдний үйлдсэн цэдгүүд үнэн гэдгийг нотлох тэдний өөрсдийнх нь гарын үсгүүдтэй гэрчилгээнүүд түүнд гардуулагдах ерөнхий цэдэг хөтлөгч байг. Дараа нь сүмийн ерөнхий цэдэг хөтлөгч гэрчилгээнүүд болон байлцсан бүх гэрчүүд хийгээд дээрх нотолгоо болон цэдгүүд үнэн гэдэгт сүмээр томилогдсон тэдгээр хүмүүсийн ерөнхий

шинж чанарын тухай мэдлэгээр тэрээр чанд итгэдэг тухай өөрийн нотолгооны хамт сүмийн ерөнхий бүртгэлийн дэвтэрт цэдгийг оруулна. Мөн энэ нь сүмийн ерөнхий бүртгэлийн дэвтэрт ормогц тэр нүдээрээ үзэж мөн чихээрээ сонсож, мөн сүмийн ерөнхий бүртгэлийн номонд үүний цэдгийг хийсэнтэй адил уг цэдэг нь ариун байж мөн ёслолд хариулах болно.

5 Юмсын энэ дэг жаяг нэн өвөрмөц байх хэмээн та нар бодож болох юм; харин энэ бол сайн мэдээний тухай “мэдлэггүйгээр нас барсан тэдний ⁶авралын тулд дэлхийн сууринаас өмнө Их Эзэн томилж мөн бэлтгэж байсан тэрхүү ёслол болон бэлтгэлийг дагаж мөрдсөнөөр гагцхүү Бурханы таалалд хариулж байгаа хэрэг гэдгийг би та нарт хэлье.

6 Мөн цааш нь, та нар Илчлэлтийн 20:12-т: “Нас барсан их бага хүмүүс Бурханы өмнө зогсож байхыг би харлаа. Номнууд дэлгээстэй байв; Өөр нэгэн ном дэлгээстэй байсан бөгөөд тэр нь амийн ном юм; Нас барагсад нь өөрсдийн үйлсийн дагуу энэхүү номд бичигдсэн зүйлсээр шүүгдэв” хэмээн тунхаглахдаа Илчлэгч Иохан нас барагсадтай холбогдуулан чухамхүү энэ асуудлаар тунгаан бясалгаж байсныг та нар санахыг би та нараас хүсч байна.

7 Уг номнууд нээгдсэн байсныг та нар энэ ишлэлд олж мэдэх болно; мөн “амьдралын ном болох өөр нэг ном нээгдсэн байлаа; гэвч нас барагсад ажлуудынхаа дагуу уг номнуудад бичигдсэн тэдгээр зүйлүүдээр шүүгдсэн байлаа, иймээс, дурдагдсан тэрхүү номнууд тэдний ажлуудын тухай цэдгийг агуулж, мөн дэлхий дээр хөтлөгддөг тэрхүү ⁶цэдгүүдээс иш татдаг бөлгөө. Мөн амьдралын ном болох тэр ном бол тэнгэрт хөтлөгддөг цэдэг болой, илчлэлтэд та нарт зарлиг болгогддог тэрхүү номлолтой яг дүйцэхүйц зарчим та нарын бүх цэдэгт энэ нь тэнгэрт тэмдэглэгдсэн байж болох байсан газраа орхиж явахын өмнө та нарт бичсэн миний захидалд агуулагдсан бөлгөө.

8 Эдүгээ, энэхүү ёслолын мөн чанар нь Есүс Христийн илчлэлтээр санваарын “хүчнээс бүрддэг, та нар дэлхий дээр юуг ч ⁶холболоо гэсэн, тэнгэрт холбогдох болно, мөн та нар дэлхий дээр юуг ч цуцаллаа гэсэн тэнгэрт цуцлагдах болно гэдэг нь энд өгөгддөг буюу. Эсвээс, өөрөөр хэлбэл, орчуулгын өөр талаас нь авч үзэн, та нар дэлхий дээр юуг ч цэдэглэлээ гэсэн тэнгэрт цэдэглэгдэх болно, мөн та нар дэлхий дээр юуг ч цэдэглэхгүй байлаа гэхэд тэнгэрт цэдэглэгдэх нь үгүй;

5а 1 Петр 4:6.
б су Нас барагсдын аврал.
7а Илч. 20:12;

С ба Г 127:6–7.
су Амьдралын ном.
б С ба Г 21:1.

8а су Хүч; Санваартан.
б су Лацдах, Лацдалт.

учир нь уг номнуудаас та нарын нас барагсад ажлуудынхаа дагуу, өөрсдийнхөө зохих хүнээр уг “ёслолуудад тэд өөрсдөө оролцсон буюу эсвээс өөрсдийгөө төлөөлсөн тэдний арга замаар, дэлхийн суурины өмнөх үеэс тэдний ‘авралын тулд Бурханы бэлтгэсэн ёслолын дагуу, өөрсдийнхөө нас барагсдын талаар тэдний хөтөлсөн цэдгүүдийн дагуу шүүгдэх болно.

9 Дэлхий дээр цэдэглэдэг буюу холбодог хүч нь мөн тэнгэрт холбодог хэмээн бид ярьдаг нь нэн зоримог номлол юм гэж заримд нь санагддаг байж болох юм. Гэсэн хэдий ч, дэлхийн бүх үеүдэд, Их Эзэн жинхэнэ илчлэлтээр хүнд, эсвээс ямар нэг хэсэг хүнд санваарын “эрин үеийг хэдийд ч өглөө гэсэн, энэхүү хүч цаг ямагт өгөгдсөөр ирсэн билээ. Эндээс, тэдгээр хүмүүс “эрх мэдлээр Их Эзэний нэрээр юуг ч хийлээ гэсэн, мөн үүнийг зөвөөр мөн итгэлтэйгээр хийж, мөн тэрхүү зүйлийн тухай зохих ёсны хийгээд итгэл бүхий цэдэг хөтлөхөд, энэ нь дэлхий дээр хийгээд тэнгэрт хууль болж, агуу их “Иеховагийн тогтоолуудын дагуу, хүчингүй болох нь үгүй бөлгөө. Энэ бол итгэгдсэн айлдвар болой. Хэн үүнийг сонсож болох билээ?

10 Мөн дахин, жишээ нь, Матай16:18, 19-д: *Би мөн чамд хэлье. Чи бол Петр энэ хадан дээр Би өөрийн чуулганыг босгох бөгөөд түүнийг Үхэгсдийн орны хаалга дийлэхгүй. Би чамд тэнгэрийн хаанчлалын түлхүүрийг өгнө. Чи газар дээр юуг ч холбоно, тэр нь тэнгэрт холбогдоно. Газар дээр юуг тайлна, тэр нь тэнгэрт тайлагдах болно гэжээ.*

11 Эдүгээ бидний өмнө байгаа бүхэл асуудлын агуу хийгээд их нууц мөн бүхэл сэдвийн *төгс сайн тал нь* Ариун Санваарын хүчнүүдийг олж авахад байдаг. Учир нь эдгээр “түлхүүрүүд өгөгдсөн түүнд хүмүүний үрс, амьд байгаа хүмүүс болон нас барагсдын аль алиных нь “авралтай холбогдсон баримтуудын мэдлэгийг олж авах нь хэцүү биш болой.

12 Үүнд “алдар суу хийгээд “хүндэтгэл, мөн “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдрал буй — усаар баптисм хүртэх ёслол, үхэлтэй адилтган хариулахын тулд усанд ‘умбуулдаг нь нэг зарчим нөгөөтэйгөө нийцсэн байхын тулд буюу; усанд умбуулагдаж мөн уснаас гарч ирэх нь нас барагсад булшнаасаа амилан урагш гарч ирэхтэй адилтгасан буюу; эндээс харахад энэхүү ёслол нь нас

8в су Ёслолууд.
г су Нас барагсдын аврал.
9а су Эрин үе.
б су Эрх мэдэл.
в су Иехова.

11а су Санваарын түлхүүрүүд.
б су Аврал.
12а су Алдар суу.
б су Хүндэтгэл.
в су Мөнх бус, Мөнх

бус байдал.
г су Баптисм,
Баптисм хүртээх—
Умбуулах баптисм.

барагсадтай адилтгагдсан нас барагсдын төлөөх баптисмын ёслолтой холбогдох хэлхээ холбоог бий болгохоор үндэслэгдсэн болой.

13 Иймээс, “баптисмын сан нь булшийг ^бдуурайлган бий болгосон бөгөөд амьд байгаа хүмүүс болон нас барагсдыг урагш үзүүлэхийн тулд, дор амьд байгаа хүмүүс цугларч дассан газар байхаар зарлиглагдсан болой, мөн бүх зүйл өөрсдийн адил төстэй байдалд байж болохын тулд, мөн тэдгээр нь нэг нь нөгөөтэйгөө нийцсэн байхын тулд — 1 Коринт 15:46, 47 мөн 48-д Паулын тунхагласанчлан, тэнгэрлэг болох тэрхүү зүйлд дэлхийн болох тэрхүү зүйлийг дагаж мөрдөхийн тулд буюу;

14 Харин эхлээд сүнслэг нь бус, төрөлх нь байдаг. Дараа нь сүнслэг нь байдаг. Анхны хүн нь газрын хөрснөөс, хоёр дахь хүн нь тэнгэрээс юм. Хөрснөөс буй нь ямар байдагчлан хөрснөөс буй тэд тийм байх бөгөөд тэнгэрээс буй нь ямар байдагчлан тэнгэрээс буй тэд тийм байна. Мөн дэлхий дээрх та нарын нас барагсдын талаар цэдгүүд зөвөөр хийгдсэн билээ, мөн түүнчлэн тэнгэр дэх цэдгүүд ч тийм болой. Тиймийн тул, энэ нь ^алацдах мөн холбох хүч бөлгөө, мөн энэхүү үгийн нэг утгаар бол, ^бмэдлэгийн

түлхүүрээс бүтдэг хаант улсын ^атүлхүүрүүд билээ.

15 Мөн эдүгээ, эрхэм хайрт ах эгч нар минь, эдгээр нь бидний авралд хамааралтайн хувьд, нас барагсад хийгээд амьд байгаа хүмүүстэй холбогдсон зарчмуудад хөнгөмсгөөр хандах ёсгүйг би баттайгаар хэлж байна. Учир нь тэдний “аврал шаардлагатай бөгөөд бидний авралд зайлшгүй чухал бөлгөө. Эцгүүдийн талаар Паулын хэлсэнчлэн — бидэнгүйгээр тэд ^бтөгс болгогдож чадах нь үгүй — мөн өөрсдийн нас барагсадгүйгээр бид төгс болгогдож чадах нь үгүй болой.

16 Мөн эдүгээ, нас барагсдын төлөөх баптисмд холбогдуулан би та нарт өөр нэг ишлэл 1 Коринт 15:29-ийг дурдъя: *Тийм биш бол үхэгсдийн төлөө баптисм хүртэгч нь юу хийж байгаа хэрэг вэ? Хэрэв үхэгсэд амилуулагдахгүй юм бол юунд тэдний төлөө хүмүүс баптисм хүртдэг вэ?*

17 Мөн дахин, энэ ишлэлтэй холбогдуулан, санваарын “сэргээлт, эцсийн өдрүүдэд илчлэгдэх ёстой алдар суунууд, мөн үүрдийн сайн мэдээнд хамаарах бүх сэдвээс хамгийн алдартай нь, нэрлэвэл нас барагсдын төлөөх баптисмд өвөрмөц маягаар мэлмийгээ тогтоосон бошиглогчдын нэгнээс нь би та

13а С ба Г 124:29.
б су Бэлэгдлийн.
14а су Лацдах,
Лацдалт.
б исо, Лук 11:53.

в су Санваарын
түлхүүрүүд.
15а су Нас барагсдын
аврал.
б Евр. 11:40.

су Төгс.
17а су Сайн мэдээний
сэргээлт.

нарт иш татъя; учир нь Малахи, сүүлчийн бүлэг 5-р мөн 6-р шүлэгт: *Харагтун, Эзэний агуу, аймшигт өдөр ирэхээс өмнө Би эш үзүүлэгч* ⁶*Елиаг та нар уруу илгэгнт. Тэрээр эцгүүдийн зүрхийг хүүхдүүд уруу нь, хүүхдүүдийн зүрхийг эцгүүд уруу нь эргүүлнэ. Эс бөгөөс Би ирж, энэ нутгийг хараалаар цохино* хэмээн хэлсэн байдаг.

18 Би үүнд арай “энгийн орчуулга хийж болох байсан, гэвч энэ нь миний зорилго хэрэгжсэн байхад хангалттай энгийн ажгуу. Энэ тохиолдолд, хэрэв эцгүүд хийгээд хүүхдүүдийн хооронд ямар нэгэн зүйлээр ямар нэгэн төрлийн гагнагч ⁶холбоо эс байх аваас дэлхий зүхлээр цохигдох болно гэдгийг мэдэх нь хангалттай юм—мөн энэ зүйл юу вэ гэдгийг болгоогтун. Энэ бол нас барагсдын төлөөх “баптисм бөлгөө. Учир нь бид тэдэнгүйгээр төгс болгогдож чадах нь үгүй; мөн тэд ч бидэнгүйгээр төгс болгогдож чадах нь үгүй. Мөн тэд ч, бас бид ч, сайн мэдээнд тэрчлэн нас нөгчсөн тэдэнгүйгээр төгс болгогдож чадах нь үгүй; учир нь Адамын өдрүүдээс бүр өнөө үеийг хүртэл тэрхүү бүхэл хийгээд бүрэн дүүрэн мөн төгс нэгдэл, мөн эрин үеүд, мөн түл-

хүүрүүд, мөн хүчнүүд, мөн алдар суунуудыг нэгтгэх гагналт тохиож мөн илчлэгдэх нь цаг хугацааны ‘бүрэн байдлын эрин үеийн эхлүүлэлтэд зайлшгүй чухал билээ, мөн энэ нь эдүгээ ирж эхэлж буй эрин үе болой. Мөн ганцхан энэ нь төдийгүй, харин дэлхийн ⁶сууринаас огт илчлэгдээгүй байсан, мөн ухаалаг цэцэн хийгээд хашир хэрсүү тэднээс нуугдсан тэдгээр зүйлүүд ⁶нялхас хийгээд хөхүүл хүүхдүүдэд энэхүү цаг хугацааны бүрэн байдлын эрин үед илчлэгдэх болно.

19 Эдүгээ, бид өөрсдийн хүлээн авсан сайн мэдээнд юуг сонсдог вэ? Баяр баясгалангийн дуу хоолойг! Тэнгэрээс нигүүлслийн дуу хоолойг; мөн газраас “үнэний дуу хоолойг; мөн нас барагсдын талаарх баярт мэдээнүүдийг; амьд байгаа хүмүүс хийгээд нас барагсдын талаарх баярт мэдээний дуу хоолойг; агуу их баяслын баярт ⁶мэдээг буюу. Болгоогтун, та нарын Бурхан хаанчилна! Кармелын “шүүдэр лугаа адил тийнхүү Бурханы тухай мэдлэг тэдэн дээр буух болно хэмээн Сионд хэлэн сайн зүйлүүдийн баярт мэдээг авчирдаг тэдний ‘хөл уулс дээр хичнээн үзэсгэлэнтэй вэ!

176 З Ниф. 25:5–6;

С ба Г 2:1–3;

110:13–16.

су Елиа.

18a ИС—Т 1:36–39.

б су Удмын бичиг;

Ёслолууд—Бусдын

өмнөөс үйлдэх

ёслол.

в С ба Г 124:28–30;

127:6–7.

г су Эрин үе.

д С ба Г 35:18.

е Мат. 11:25;

Лук 10:21;

Алма 32:23.

19a Дуул. 85:10–11.

б Лук 2:10.

в Дэд хууль 32:2;

С ба Г 121:45.

г Иса. 52:7–10;

Мозая 15:13–18;

3 Ниф. 20:40.

20 Мөн дахин, бид юу сонсдог вэ? “Куморагаас баярт мэдээг! Тэнгэрээс бошиглогчдын биелэлт — илчлэгдэх ёстой ⁶номыг тунхаглах тэнгэр элч ⁶Моронайг. Сенека гүнлэгийн ⁷Фейеттегийн аглаг буйдад номыг ⁸гэрчлэхийг гурван гэрчид тунхаглах Их Эзэний дуу хоолойг! ⁹Гэрлийн тэнгэр элчийн дүрээр чөтгөр хүрч ирэхэд түүнийг таньсан ⁹Михайлын дуу хоолойг Сасквиеханнагийн эрэг дээр! Хаант улсын ^{*}түлхүүрүүдийг, мөн цаг хугацааны бүрэн байдлын эрин үеийг эзэмшигчид хэмээн Хармонийн Сасквиеханна гүнлэг, мөн Колесвилл, Брум гүнлэгийн хоорондох аглаг буйдад, Сасквиеханна гол дээр өөрсдийгөө тунхаглагч ³Петр, Иаков, Иохан нарын дуу хоолойг буюу!

21 Мөн дахин, Сенека Гүнлэгийн Фейеттед, мөн өөр өөр үед, мөн янз янзын газрууд дахь Есүс Христийн Хожмын Үеийн энэ Сүмийн бүх аялал хийгээд зовлон зүдгүүрүүдээр дамжуулан өвгөн “Эцэг Витмерийн өрөөн дэх Бурханы дуу хоолойг буюу! Мөн

тэргүүн тэнгэр элч Михайлын дуу хоолойг; бүгд өөрсдийн ⁶эрин үе, өөрсдийн эрхүүд, өөрсдийн түлхүүрүүд, өөрсдийн алдар хүндэтгэлүүд, өөрсдийн сүр жавхлан хийгээд алдар суу, мөн өөрсдийн санваарын хүчийг тунхаглагч, шат шатаар, ⁹дүрэм дүрмээр, энд бяцхан мөн тэнд бяцханыг бидний ⁷найдварыг батлан, ирэх тэр зүйлийг урагш гаргаснаар бидэнд тайвшралыг өгдөг ⁹Габриелын мөн ⁹Рафаелын, мөн Михаил буюу ⁹Адамаас доош өнөө үеийг хүртэлх бусад ^{*}тэнгэр элчүүдийн дуу хоолойг буюу.

22 Ах дүүс минь, ийм агуу учир шалтгааны төлөө бид урагш явахгүй гэж үү? Арагшаа биш, харин урагшаа явагтун. Зориглогтун, ах дүүс минь тэгээд ялалт өөд ахь ахь! Зүрх сэтгэл чинь баясаг, мөн үлэмжийн баяртай байг. Дэлхий гэнэт дуу “дуулж эхлэг. Дэлхий байхаас өмнө, тэднийг ⁶шоронгоос ⁶гэтэлгэх боломжийг бидэнд олгосон тэр зүйлийг тогтоосон ⁷Иммануелын Хаанд мөнхийн магтаалын сүлд дууллыг нас

20a ИС—Т 1:51–52.
 су Кумора гүвээ.
 б Иса. 29:4, 11–14;
 2 Ниф. 27:6–29.
 су Мормоны Ном.
 в су Моронай,
 Мормоны хүү.
 г су Фейетте, Нью-
 Йорк (АНУ).
 д С ба Г 17:1–3.
 е 2 Кор. 11:14.
 ё С ба Г 27:11.

су Адам.
 ж су Санваарын
 түлхүүрүүд.
 з С ба Г 27:12.
 21a өх Ахмад Петр
 Витмер.
 б су Эрин үе.
 в Иса. 28:10.
 г су Найдвар.
 д су Габриел.
 е су Рафаел.
 ё С ба Г 107:53–56.

ж су Тэнгэр элчүүд.
 22a Иса. 49:13.
 б Иса. 24:22;
 С ба Г 76:72–74.
 в су Гэтэлгэх,
 Гэтэлгэгдэх,
 Гэтэлгэл.
 г Иса. 7:14;
 Алма 5:50.
 су Иммануел.

барагсад урагш өргөг; учир нь хоригдлууд чөлөөтэйгөөр явах болно.

23 Баяр хөөрийн учир “уулс хашгираг; мөн хөндийнүүд та нар бүгдээрээ чанга хашгирагтун; мөн тэнгис далайнууд хийгээд хуурай газрууд та нар бүгдээрээ Мөнхийн Хааныхаа тухай гайхамшгуудыг өгүүлэгтүн! Мөн та нар, гол мөрнүүд мөн горхиуд мөн жижиг горхиуд та нар баяр хөөрөөр цутган урсагтун. Ойнууд хийгээд хээрийн бүх модод Их Эзэнийг магтаг; хатуу ^бхаднууд та нар баяр хөөрийн улмаас уйлагтун! Мөн нар, сар, мөн ^вүүрийн одод хамтдаа дуулаг, мөн Бурханы бүх хүүхэд баяр хөөрийн улмаас хашгираг! Мөн мөнхийн бүтээлүүд түүний нэрийг үүрд мөн мөнхөд тунхаглаг. Мөн дахин би хэлнэ, бидний чихэнд алдар сууг, мөн авралыг, мөн алдар хүндэтгэл, мөн ^гүхэшгүй байдал, бас ^дмөнх амьдралыг хаант улсууд, вант улсууд мөн хүчнүүдийг тунхаглах — тэнгэрээс бидний сонсдог тэрхүү дуу хоолой хичнээн агуу алдар суутай билээ!

24 Болгоогтун, Их Эзэний “агуу өдөр ойрхон байна; мөн

түүний ирэлтийн өдрийг хэн ^бтэсвэрлэж, мөн түүнийг хүрч ирэхэд хэн зогсоогоороо үлдэж чадах билээ? Учир нь тэрбээр алт тунгаагчийн ^вгал лугаа адил, мөн хувцас угаагчийн саван мэт билээ; мөн тэрбээр мөнгө ^гтунгаагч мөн цэвэршүүлэгчийн адил суух болно, мөн тэд зөв шударга байдалд Их Эзэнд ^дөргөл барьж болохын тулд тэрээр ^еЛевийн хөвгүүдийг цэвэршүүлж, мөн тэднийг алт хийгээд мөнгө лугаа адил ангижруулан цэвэрлэх болно. Тиймийн тул, бид сүм болон хүмүүсийн хувьд, мөн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хувьд Их Эзэнд зөв шударга байдалд өргөл өргөцгөөе; Түүний ариун сүмийг дуусахад хүлээн зөвшөөрөх бүх зүйлээс зохистой нь болох бидний нас барагсдын ^зцэдгүүдийг агуулагч номыг тэнд байлгагцаага.

25 Ах дүүс минь, энэ сэдвээр та нарт хэлэх олон зүйл надад буй; гэвч энэ удаад эдүгээ хааж, мөн сэдвийг өөр үед үргэлжлүүлэх болно. Бибээр үүрд та нарын даруухан үйлчлэгч мөн хэзээ ч үл хувирах найз билээ.

ИОСЕФ СМИТ

23а Иса. 44:23.

б Лук 19:40.

в Иов 38:7.

г су Мөнх бус, Мөнх бус байдал.

д су Мөнх амьдрал.

24а су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

б Малах. 3:1–3.

в 3 Ниф. 24:2–3.

су Дэлхий—

Дэлхийн

цэвэршилт.

г Зех. 13:9.

д С ба Г 84:31.

су Өргөл.

е Дэд хууль 10:8;

С ба Г 13:1; 124:39.

ё С ба Г 127:9.

су Удмын бичиг.

ХЭСЭГ 129

1843 оны хоёрдугаар сарын 9-нд Иллинойн Наувуд, тохинуулагч тэнгэр элчүүд хийгээд сүнснүүдийн мөн чанар ялгагдан танигдаж болох гурван их түлхүүрийг илчилсэн, Бошиглогч Иосеф Смитээр өгөгдсөн зааврууд оршивой (History of the Church, 5:267).

1–3, Амилуулагдсан хийгээд сүнсэн биеүд аль аль нь тэнгэрт буй; 4–9, Хошигний цаанаас элчүүд танигдаж болох түлхүүрүүд өгөгдөв.

ТЭНГЭРТ хоёр төрлийн хүмүүн биет, тухайлбал: ^бАмилуулагдсан хүмүүн болох махан бодь хийгээд яс бүхий ^втэнгэр элчүүд буй—

2 Жишээ нь: *Надад гараа хүргэж мөн үзэгтүн, учир нь сүнс “мах хийгээд ясгүй болой, харин надад буйг та нар харж байна хэмээн Есүс хэлжээ.*

3 Хоёрдугаарт: төгс болгогдсон “шударга хүмүүсийн ^бсүнснүүд, тэд амилуулагдаагүй боловч мөнхүү алдар сууг өвлөдөг болой.

4 Элч ирж, Бурханаас захиас авчирлаа хэмээн түүнийг хэлэхэд, түүнд гараа өгч мөн өөртэйгөө гар барихыг түүнээс хүс.

5 Хэрэв тэрбээр тэнгэр элч байх аваас, тэрээр үүнчлэн үйлдэх болно, мөн та

нар түүний гарыг мэдрэх болно.

6 Хэрэв тэрбээр төгс болгогдсон шударга хүний сүнс байх аваас, тэрбээр өөрийн алдар сууд ирэх болно; учир нь энэ бол түүний хүрч ирж болох цорын ганц зам болой—

7 Өөртэйгөө гар барихыг түүнээс хүс, харин тэрээр хөдлөхгүй байх болно, учир нь шударга хүн хууран мэхлэх нь тэнгэрийн тогтсон журамд харш бөлгөө; гэвч тэрбээр түүний захиасыг хүргэсээр байх болно.

8 Хэрэв энэ нь гэрлийн тэнгэр элч адил “чөтгөр байх аваас, гар барихыг та нар түүнээс хүсэхэд, тэрбээр та нарт гараа өгөх болно, мөн та нар юу ч мэдрэхгүй байх болно; тиймийн тул та нар түүнийг ялган таньж болох бөлгөө.

9 Эдгээр нь аливаа үйлчлэл Бурханаас уу гэдгийг та нар мэдэж болох тэрхүү гурван их түлхүүр бөлгөө.

ХЭСЭГ 130

1843 оны дөрөвдүгээр сарын 2-нд Иллинойн Рамуст Бошиглогч Иосеф Смитээр өгөгдсөн зааврын зүйлүүд оршивой (History of the Church, 5:323–325).

129 1а су Тэнгэр.
б су Амилуулалт.
в су Тэнгэр элчүүд.

2а Лук 24:39.
3а Евр. 12:23;
С ба Г 76:69.

б су Сүнс.
8а 2 Кор. 11:14;
2 Ниф. 9:9.

1–3, Эцэг болон Хүү хүмүүн дээр биеэрээ залран ирж болно; 4–7, Тэнгэр элчүүд селестиел хүрээнд оршин суудаг; 8–9, Селестиел дэлхий нь агуу Урим ба Туммим байх болно; 10–11, Селестиел дэлхийд орох тэд бүгдэд цагаан чулуу өгөгддөг; 12–17, Хоёр дахь Ирэлтийн цаг бошиглогчид өгөгдөөгүй болой; 18–19, Энэ амьдралд хуримтлуулсан оюун билэг Амилуулалтад бидэнтэй хамт сэргэн босдог; 20–21, Хуулийг дуулавартай дагаснаар бүх адислал ирдэг; 22–23, Эцэг, Хүү хоёр мах хийгээд ясан биетэй.

АВРАГЧИЙГ “залран ирэхэд бид түүнийг байгаагаар нь харах болно. Тэрээр бидэнтэй адилхан ^бхүн гэдгийг бид харах болно.

2 Энд бидний дунд байгаа тэрхүү харилцаа тэнд бидний дунд байх болно, гагцхүү энэ нь эдүгээ бидний эдэлдэггүй тийм алдар суу болох “мөнхийн алдар суугаар хоёр дахин ихсэх болно.

3 Иохан 14:23—энэ шүлэг дэх “Эцэг, ^бХүү хоёр залран ирсэн нь хүмүүнд биеэрээ “залран ирсэн болой; мөн Эцэг, Хүү хоёр хүмүүний зүрх

сэтгэлд ‘оршдог гэсэн үзэл бодол нь хуучин шашны бүлэглэлийн төсөөлөл бөгөөд энэ нь буруу болой.

4 Тэдний оршин суудаг гарагийн дагуу Бурханы “цаг, тэнгэр элчийн цаг, бошиглогчийн цаг, мөн хүмүүний цагийг тооцдоггүй юу? хэмээх асуултын хариуд,

5 Тийм ээ, хэмээн би хариулна. Харин үүнд харьяалагддаг буюу харьяалагдаж ирснээс бусдаар энэ дэлхийд тохинуулдаг “тэнгэр элчүүд гэж үгүй болой.

6 Тэнгэр элчүүд энэ дэлхийтэй адилхан гараг дээр оршин суудаггүй бөлгөө;

7 Харин тэд Бурханы дэргэд, тэдний алдар суугийн тулд бүх зүйл өнгөрсөн, одоо ба ирээдүй үзүүлэгдэн, мөн Их Эзэний өмнө үргэлжлэн байдаг шилэн хийгээд “галан ^бтэнгис лугаа адил бөмбөрцөг дээр оршин суудаг бөлгөө.

8 Бурхан оршин суудаг газар бол агуу “Урим ба Туммим болой.

9 Энэ “дэлхий өөрийн ариусагдсан хийгээд үхэшгүй байдалд, үүн дээрх оршин суугчдад болор лугаа адил болгогдох болно, мөн үүгээр

130 1a 1 Иохан 3:2;
Моро. 7:48.
су Есүс Христийн
Хоёр дахь Ирэлт.
б Лук 24:36–40.
2a су Селестиел
алдар суу.
3a су Бурхан, Бурхан
тэргүүтэн—Эцэг
Бурхан.
б су Бурхан, Бурхан

тэргүүтэн—Хүү
Бурхан.
в С ба Г 93:1.
г С ба Г 130:22.
су Бурхан, Бурхан
тэргүүтэн.
4a 2 Петр 3:8,
Абр. 3:4–10,
Абрахамын номон
дахь Зураг 1,
хуулбар 2-ыг бас үз.

5a су Тэнгэр элчүүд.
7a Иса. 33:14;
С ба Г 132:1–3.
б Илч. 4:6; 15:2.
8a су Урим ба
Туммим.
9a С ба Г 77:1.
су Дэлхий—
Дэлхийн эцсийн
байдал.

захирагдмал хаант улс буюу доогуур жаягийн хаант улсуудад хамаарах бүх зүйл үүн дээр оршин суудаг тэндэнд үзүүлэгдэх болно, мөн энэ дэлхий Христийнх байх болно.

10 Тийнхүү Илчлэлтийн 2:17-д дурдагддаг цагаан чулуу нь, хүлээн авах хувь хүн болгонд Урим ба Туммим болох буюу, хаант улсуудын илүү өндөр дэг жаягт хамаарах зүйлүүд үүгээр мэдүүлэгдэх болно.

11 Мөн үүнийг хүлээн авдаг түүнээс бусад хүн мэдэхгүй шинэ “нэрийг дээр нь бичсэн” цагаан чулуу селестиел хаант улсад ирдэг хүн болгонд өгөгддөг ажгуу. Тэрхүү шинэ нэр бол түлхүүр үг бөлгөө.

12 Хүний Хүүгийн ирэлтийн өмнө их цус урсгахад хүргэх тэрхүү “бэрхшээлүүдийн эхлэл нь” Өмнөд Каролинд байх болно гэдгийг Их Эзэн Бурханы нэрээр би бошиглож байна.

13 Энэ нь боолчлолын асуудлаар дамжин үүсэх магадлалтай болой. Энэ нь 1832 оны арванхоёрдугаар сарын 25-нд намайг шаргуугаар залбирч байхад надад тунхаглагдсан дуу хоолой бөлгөө.

14 Хүний Хүүгийн “ирэл-

тийн цагийг мэдэхээр нэг удаа намайг шаргуугаар залбирч байхад дараах зүйлийг давтан өгүүлсэн дуу хоолойг би сонсож билээ:

15 Иосеф, хүү минь, хэрэв чи наян таван нас хүртэл амьдрах аваас, чи Хүний Хүүгийн нүүрийг үзэх болно; тиймийн тул, энэ нь хангалттай байг, мөн энэ асуудлаар надад дахин төвөг удахаа боль.

16 Ийнхүү энэхүү ирэлт нь мянган жилийн эхлэлд хамаарах уу эсвэл арай эрт тохиох уу гэдгийг, эсвээс би үхэх учиртай юу гэдгийг, мөн тийн түүний нүүрийг үзэх эсэхийг шийдэж чадалгүйгээр би хоцров.

17 Хүний Хүүгийн ирэлт нь тэр цагаас яав ч эрт байх нь үгүй гэдэгт би итгэнэ.

18 Бид энэ амьдралд “оюун билгийн ямар ч түвшинд хүрлээ гэсэн, энэ нь” амилуулалтад бидэнтэй хамт сэргэн босох болно.

19 Мөн хэрэв хүн өөрийн “хичээл зүтгэл мөн” дуулгавартай байдлаар дамжуулан бусдаас илүү “мэдлэг мөн оюун билгийг энэ амьдралд хуримтлуулах аваас, тэрээр ирэх дэлхийд маш ‘их давуу талтай байх болно.

20 Энэ дэлхийн сууринаас “өмнө дээр нь бүх” адислал

11а Иса. 62:2.

б Илч. 2:17.

12а С ба Г 38:29; 45:63.

б С ба Г 87:1–5.

14а су Есус Христийн Хоёр дахь Ирэлт.

18а су Оюуны өндөр хөгжил.

б су Амилуулалт.

19а су Хичээл зүтгэл.

б су Дуулгавартай байх, Дуулгавартай дагах.

в су Мэдлэг.

г Алма 12:9–11.

20а су Мөнх бус

байдлын өмнөх амьдрал.

б Дэд хууль 11:26–28; С ба Г 132:5.

су Адислах, Адислагдах, Адислал.

тулгуурлагдсан “хууль тэнгэрт эргэлт буцалтгүйгээр тогтоогдсон болой —

21 Мөн бид ямар ч адислалыг Бурханаас авлаа гэхэд, энэ нь тулгуурлагдсан тэрхүү хуульд дуулгавартай байснаар буюу.

22 “Эцэг хүмүүнийхтэй адил мэдрэгдэх мах хийгээд ясан ^ббиетэй болой; Хүү ч бас адил

бөлгөө; харин “Ариун Сүнс бол мах хийгээд ясан биегүй харин Сүнсэн хүн буюу. Ийм бус байх аваас, Ариун Сүнс бидэн дотор оршиж чадах нь үгүй бөлгөө.

23 Хүн “Ариун Сүнсийг хүлээн авч болно, мөн энэ нь түүн дээр бууж ирж болох бөгөөд түүнтэй хамт үлдэх нь үгүй.

ХЭСЭГ 131

1843 оны тавдугаар сарын 16 мөн 17-нд Иллинойн Рамуст Бошиглогч Иосеф Смитээр өгөгдсөн зааврууд оршвой (History of the Church, 5:392–393).

1–4, Селестиел гэрлэлт нь хамгийн дээд тэнгэр дэх өргөмжлөлд зайлшгүй чухал; 5–6, Хүмүүн мөнх амьдралд хэрхэн лацдагдах нь тайлбарлагдав; 7–8, Бүх сүнс бол матери мөн.

“СЕЛЕСТИЕЛ алдар сууд Сурван тэнгэр буюу зэрэглэл буй;

2 Мөн “хамгийн дээдхийг нь олж авахын тулд хүн санваарын энэхүү ариун жаягт [^бгэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээг хэлж буй] орох ёстой;

3 Мөн хэрэв тэрээр үгүй

аваас, тэрээр үүнийг олж авч чадах нь үгүй.

4 Тэрээр нөгөөд нь орж болно, гэвч тэр нь түүний хаант улсын төгсгөл болой; тэрээр “өсөн нэмэгдэж үл чадна.

5 (1843 оны тавдугаар сарын 17) “Бошиглолын илүү баттай үг гэсний утга нь тэрээр Ариун санваарын хүчээр дамжуулан илчлэлтээр мөн бошиглолын сүнсээр ^бмөнх амьдралд “лацдагдахыг хүн мэдэх нь болой.

6 “Юу ч мэдэхгүйгээр ^баврагдах нь хүмүүний хувьд боломжгүй бөлгөө.

20в С ба Г 82:10.

22а су Бурхан, Бурхан тэргүүтэн.

б Үйлс 17:29.

в су Ариун Сүнс.

23а су Ариун Сүнсний бэлэг.

131 1а С ба Г 76:70.

су Селестиел

алдар суу.

2а С ба Г 132:5–21.

су Өргөмжлөл.

б су Гэрлэлт, Гэрлэх—

Гэрлэлтийн

шинэ бөгөөд

үүрдийн гэрээ.

4а С ба Г 132:16–17.

5а 2 Петр 1:19.

су Дуудлага ба

Сонгогдогсод.

б су Мөнх амьдрал.

в С ба Г 68:12; 88:4.

су Лацдах,

Лацдалт.

6а С ба Г 107:99–100.

б су Аврал.

7 Бодит бус матери лугаа адил зүйл гэж үгүй. Бүх “сүнс матери мөн, харин энэ нь илүү нарийн, эсвээс цэвэр, мөн гагцхүү илүү ^бцэвэр мэлмийгээр ялгагдан танигдаж болох бөлгөө;

8 Бид үүнийг харж чадахгүй, харин бидний бие цэвэршигдсэн үед энэ нь бүгд матери болохыг бид харах болно.

ХЭСЭГ 132

1843 оны долдугаар сарын 12-нд тэмдэглэгдсэн, шинэ бөгөөд үүрдийн гэрээ, түүний дотор гэрлэлтийн гэрээний үүрд мөнхийн чанар, мөн тэрчлэн олон эхнэртэй байх ёсонд холбогдуулан Иллинойн Наувуд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оривой (History of the Church, 5:501–507). Хэдийгээр уг илчлэлт 1834 онд цэдэглэгдсэн ч, уг илчлэлтэд орсон сургаалууд хийгээд зарчмууд нь 1831 оноос Бошиглогчоор мэдүүлэгдсэнийг түүхийн цэдгүүд нотолж байгаа ажээ.

1–6, Өргөмжлөл нь шинэ бөгөөд үүрдийн гэрээгээр дамжин олддог; 7–14, Уг гэрээний болзлууд хийгээд нөхцөлүүд толилуулагдав; 15–20, Селестиел гэрлэлт болон гэр бүлийн нэгжийн үргэлжлэл нь хүмүүст бурхад болох боломжийг олгодог; 21–25, Шулуун бөгөөд нарийн зам мөнх амьдралуудад хөтөлдөг; 26–27, Ариун Сүнсний эсрэг доромжлохтой холбогдсон хууль өгөгдөв; 28–39, Мөнхийн өсөн нэмэгдэлт болон өргөмжлөлийн амлалтууд бошиглогчдод хийгээд Гэгээнтнүүдэд бүх цаг үед хийгддэг бөлгөө; 40–47, Дэлхий дээр хийгээд тэнгэрт холбох хийгээд лацдах хүч Иосеф Смитэд өгөгдөв; 48–50, Их Эзэн түүн дээр өргөмжлөлийг нь лацдав; 51–57, Итгэлтэй бөгөөд үнэнч байхыг Эмма Смитэд зөвлөв; 58–66, Олон

эхнэртэй байх ёсыг зохицуулах хууль толилуулагдав.

ҮНЭНЭЭР, Их Эзэн намайг Өөрийн үйлчлэгчид Абрахам, Исаак, мөн Иаков, бас тэрчлэн Мосе, Давид болоод Соломон нар олон “эхнэр хийгээд татвар эмстэй байх өөрсдийн зарчим хийгээд сургаалыг баримталж байсныг зөвтгөснийг та нар хэрхэн мэдэж мөн ойлгохыг миний гараас асуусны улмаас ийн Их Эзэн өөрийн үйлчлэгч Иосефт хэлж байна —

2 Болгоогтун, мөн харагтун, бибээр Их Эзэн, чиний Бурхан билээ, мөн энэ асуудлыг хөндөн чамд хариулах болно.

3 Тиймийн тул, чамд миний өгөх гэж буй заавруудыг хүлээн авч мөн дуулгавартай

7а су Сүнс.
б С ба Г 76:12; 97:16;
Моце 1:11.

132 1а С ба Г 132:34,
37–39.
су Гэрлэлт,

Гэрлэх—Олон
эхнэр авах ёс.

дагахад зүрх сэтгэлээ “бэлтгэгтүн; учир нь энэхүү хууль өөрсдөд нь илчлэгдсэн тэд бүгд мөн үүнийг дуулгавартай дагах ёстой.

4 Учрыг болгоогтун, шинэ бөгөөд үүрдийн “гэрээг би та нарт илчилж байна; мөн хэрэв та нар тэр гэрээг үл баримталбаас, тэгвэл та нар ^бяллагдах болой; учир нь энэ гэрээг “эсэргүүцэх хэнд ч гэсэн, мөн миний алдар сууд орох нь үл зөвшөөрөгдөх болно.

5 Учир нь миний гараас “адислалыг хүлээн авахыг хүсэх тэд бүгд тэрхүү адислалын тулд өгөгдсөн ^бхуулийг, мөн үүний нөхцөлүүдийг, дэлхийн сууринаас өмнө үндэслэгдэн бий болсноор нь баримтлах ёстой.

6 Мөн шинэ бөгөөд “үүрдийн гэрээнд хамаарахын хувьд, энэ нь миний ^балдар суугийн бүрэн байдлын тулд үндэслэгдсэн ажгуу; мөн үүний бүрэн байдлыг хүлээн авдаг тэрээр уг хуулийг баримтлах шаардлагатай мөн ёстой, эс бөгөөс тэрээр яллагдах болно хэмээн Их Эзэн хэлдэг.

7 Мөн үнэнээр би та нарт хэлж байна, энэхүү хуулийн “нөхцөлүүд нь эдгээр болой: Амлалтын ^бАриун Сүнсээр,

тослогдсон түүнээс, мөн түүнчлэн энэ амьдралд хийгээд үүрд мөнхийн тулд аль алинд нь хийгдээгүй мөн ороогүй, мөн “лацдагдаагүй бүх гэрээнүүд, хэлцлүүд, үүргүүд, хариуцлагууд, тангаргууд, андгайнууд, гүйцэтгэлүүд, хэлхээ холбоонууд, нийгэмлэгүүд, эсвээс найдлагууд, мөн тэрхүү хамгаас илүү ариун нь, дэлхий дээр энэ хүчийг атгахаар (мөн эцсийн өдрүүдэд энэхүү хүчийг атгахаар, бибээр өөрийн үйлчлэгч Иосефыг томилсон бөгөөд энэхүү хүч хийгээд энэ санваарын ^бтүлхүүрүүдийг олгосон хүн тухайн цаг үед зөвхөн ганцхан л байдаг бөлгөө), миний томилсон миний тослогдогсдын арга замаар дамжин “илчлэлт болон зарлигаар, нас барагсдаас амилуулагдсаны дараа үр нөлөөгүй, үр дүнгүй буюу хүчгүй юм; учир нь энэ төгсгөлд хийгдээгүй бүх хэлцлүүд хүмүүнийг нас нөгчихөд төгсгөл болдог бөлгөө.

8 Болгоогтун, миний өргөө болбоос будлихын өргөө бус, харин дэг журмын өргөө мөн хэмээн Их Эзэн хэлж байна.

9 Миний нэрэнд хийгдээгүй “өргөлийг би хүлээн зөвшөө-

3а С ба Г 29:8; 58:6; 78:7.

4а су Гэрээ.

б су Ял.

в С ба Г 131:1–4.

5а С ба Г 130:20–21.

б су Хууль.

6а С ба Г 66:2.

су Шинэ бөгөөд

үүрдийн гэрээ.

б С ба Г 76:70, 92–96.

су Селестиел

алдар суу.

7а С ба Г 88:38–39.

б су Амлалтын

Ариун Сүнс.

в су Лацдах,

Лацдалт.

г су Тангараг.

д су Санваарын

түлхүүрүүд.

е су Илчлэлт.

9а Моро. 7:5–6.

су Золиослол.

рөх үү хэмээн Их Эзэн хэлнэ гэж үү?

10 Эсвээс өөрийн “тогтоогоогүй зүйлийг бибээр та нарын гараас хүлээж авна гэж үү?

11 Мөн дэлхий байхаас өмнө би болон миний Эцэг та нарт “томилдог байсанчлан, энэ нь хуулиар байхаас бусдаар, би та нарт томилно гэж үү?

12 Бибээр Их Эзэн, чиний Бурхан билээ; мөн надаар буюу миний хууль болох миний үгээр биш бол, хүмүүн Эцэгт “ирэх нь үгүй хэмээх энэхүү зарлигийг би та нарт өгч байна хэмээн Их Эзэн хэлж байна.

13 Мөн дэлхий дээрх юм болгон, энэ нь хүмүүнээр, хаан ширээгээр эсвээс вант улсуудаар, эсвээс хүчнүүдээр, эсвээс нэр алдрын зүйлүүдээр томилогдсон ч надаар буюу миний үгээр биш болой хэмээн Их Эзэн хэлж байна, тэдгээр нь доош хаягдах болно, мөн хүмүүнийг нас нөгчсөний дараа мөн амилуулалтад буюу дараа нь үлдэх нь “үгүй хэмээн Их Эзэн хэлж байна.

14 Учир нь үлддэг ямар ч зүйл нь надаар бөлгөө; мөн надаар бус ямар ч зүйл гангаж мөн устгагдах болно.

15 Тиймийн тул, хэрэв эр хүн дэлхийд нэг эхнэртэй “гэрлэх аваас, мөн тэрээр надаар буюу миний үгээр түүнтэй үл гэрлэх аваас, мөн

тэрээр түүнтэй хамт дэлхийд байх тэрхүү урт хугацаагаар гэрээ хийж, тэдний гэрээ болон гэрлэлт нь тэднийг нас нөгчихөд, мөн тэднийг дэлхийгээс явахад, хүчингүй болох бөлгөө; тиймийн тул, тэд дэлхийгээс одох үед ямар ч хуулиар холбогдох нь үгүй бөлгөө.

16 Тиймийн тул, тэд дэлхийгээс гадна гэрлэх нь ч, мөн тэд “хадамд гарах нь ч үгүй; харин улам илүү, мөн үлэмж, мөн мөнхийн жинтэй алдар сууд зохистой тэд бүгдийн тулд тохинуулах тэнгэр дэх “тэнгэр элчүүд буюу тохинуулагч үйлчлэгчид болохоор томилогддог болой.

17 Учир нь эдгээр тэнгэр элчүүд миний хуулийг баримталдаггүй байв; тиймийн тул, тэд өргөжин тэлж чадахгүй, харин тусдаа, ганцаараа, өргөмжлөлгүйгээр, өөрсдийн аврагдсан байдалд, бүхий л үүрд мөнхөд үлдэх авай; мөн үүнээс хойш бурхад биш, харин үүрд мөн мөнхөд Бурханы тэнгэр элчүүд байдаг.

18 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, хэрэв эр хүн нэг эхнэртэй гэрлэж, мөн түүнтэй энэ амьдралд хийгээд үүрд мөнхөд гэрээ хийх аваас, хэрэв уг гэрээ надаар буюу миний хууль болох миний үгээр бус аваас, мөн энэ

10a Лев. 22:20–25;
Мосе 5:19–23.
11a С ба Г 132:5.
12a Иохан 14:6.

13a 3 Ниф. 27:10–11.
15a су Гэрлэлт, Гэрлэх.
16a Мат. 22:23–33;
Марк 12:18–25;

Лук 20:27–36.
б су Тэнгэр элчүүд.

хүчинд миний тосолж мөн томилсон түүгээр дамжуулан Ариун Сүнсээр лацдагдаагүй аваас, тэд дэлхийгээс гадна байхад хүчин төгөлдөр биш болой, учир нь тэдгээр нь надаас мөн миний үгээр ч нэгдүүлэгдээгүй билээ хэмээн Их Эзэн хэлж байна; тэд дэлхийгээс гадна байхад, энэ нь тэнд хүлээн авагдаж чадахгүй, учир нь дэргэдүүр нь өнгөрч үл чадах тэнгэр элчүүд хийгээд бурхад тэнд томилогддог; тиймийн тул, тэд миний алдар сууг өвлөж үл чадна, учир нь миний өргөө дэг журмын өргөө билээ хэмээн Их Эзэн Бурхан хэлж байна.

19 Мөн дахин, үнэнээр би та нарт хэлж байна, хэрэв эр хүн миний хууль болох миний үгээр, мөн “шинэ бөгөөд үүрдийн гэрээгээр нэг эхнэртэй гэрлэж, мөн энэ нь ^бамлалтын ариун Сүнсээр энэхүү хүч хийгээд энэхүү санваарын ^втүлхүүрүүдийг миний томилсон, тослогдсон түүгээр тэдэн дээр ^глацдагдаж, мөн — та нар эхний амилуулалтад урагш гарах болно; мөн хэрэв энэ нь эхний амилуулалтын дараа аваас, удаах амилуулалтад байх болно; мөн ^дхаан ширээнүүд, хаант улсууд, вант улсууд, мөн хүчнүүд,

эзэгнэлүүд, бүх өндөрлөгүүд хийгээд гүнүүдийг өвлөх болно хэмээн тэдэнд хэлэгдэх аваас — тэгвэл тэрээр гэмгүй цусыг урсгахаар аллага үйлдэхгүйн тулд энэ нь Хурганы Амьдралын “Номонд бичигдэх болно, мөн хэрэв та нар миний гэрээг дагах аваас, мөн үүгээр гэмгүй цусыг урсгахаар аллага үйлдэхгүй байх аваас, тэдэн дээр энэ амьдралд мөн бүх үүрд мөнхөөр дамжуулан миний үйлчлэгч тэдэн дээр юуг ч тавилаа гэсэн бүх зүйлд энэ нь тэдэнд хийгдэх болно; мөн тэднийг дэлхийгээс гадна байхад бүрэн хүчтэй хэвээр байх болно; мөн, тэдний тэргүүн дээр лацдагдсан тэрхүү алдар суу нь бүрэн дүүрэн мөн үүрд хийгээд мөнхөд үр удмынх нь хувьд үргэлжлэл байх өөрсдийн ^еөргөмжлөл хийгээд бүх зүйл дэх алдар суу тийш тэнд буй тэнгэр элчүүд, мөн бурхдын дэргэдүүр өнгөрөх болно.

20 Тэгээд тэд бурхад байх болно, учир нь тэдэнд төгсгөл гэж үгүй; тиймийн тул, тэд үүрдээс үүрдэд байх болно, учир нь тэд үргэлжилсээр байх болно; тийнхүү тэд бүхний дээр байх болно, учир нь бүх зүйл тэдэнд захирагддаг бөлгөө. Тийнхүү тэд ^жбурхад

19a су Гэрлэлт, Гэрлэх—Гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээ.
б С ба Г 76:52–53; 88:3–4.
в су Санваарын түлхүүрүүд.

г су Лацдах, Лацдалт.
д Ег. 19:5–6; Илч. 5:10; 20:6; С ба Г 76:56; 78:15, 18.
е су Амьдралын ном.
ж су Өргөмжлөл.

20a Мат. 25:21; С ба Г 29:12–13; 132:37.
су Хүмүүн, Хүмүүс—Хүн, Тэнгэрлэг Эцэгтэй адил болох боломж.

байх болно, учир нь ^ббүх хүч тэдэнд буй, мөн тэнгэр элчүүд тэдэнд захирагддаг болой.

21 Үнэнээр, үнэнээр би та нарт хэлж байна, та нар миний “хуулийг дагахаас бусдаар та нар энэхүү сүр жавхланд хүрч чадах нь үгүй.

22 Учир нь хаалга “шулуун, мөн өргөмжлөл хийгээд амьдралын ^бүргэлжлэл уруу хөтөлдөг “зам нарийхан бөгөөд үүнийг олдог нь цөөхөн болой, учир нь та нар дэлхийд намайг олох нь үгүй, мөн намайг мэдэх нь ч үгүй ажгуу.

23 Харин та нар намайг дэлхийд хүлээн авбал, тэгвэл та нар намайг мэдэх болно, мөн өргөмжлөлөө хүлээн авах болно; миний байдаг “тэнд та нар тэрчлэн байж болохын тулд буюу.

24 Энэ бол “мөнх амьдрал — гагцхүү мэргэн хийгээд үнэн Бурханыг, мөн Есүс Христийг, ^билгээгдсэн түүнийг мэдэх нь болой. Тэрээр гэдэг нь би болой. Тиймийн тул, хүлээн авцгаа та нар, миний хуулийг.

25 Хаалга нь “өргөн, мөн зам өргөн бол ^бүхэл уруу хөтөлдөг; мөн түүгээр явдаг нь

олон бөлгөө, учир нь тэд намайг “хүлээн авдаггүй, мөн тэд миний хуулийг мөрддөггүй билээ.

26 Үнэнээр, үнэнээр би та нарт хэлж байна, хэрэв эрэгтэй хүн миний үгийн дагуу эхнэртэйгээ гэрлэж, мөн тэд миний томилолтын дагуу, амлалтын “Ариун Сүнсээр лацдагдах аваас, мөн эрэгтэй нь ч, эмэгтэй нь ч аливаа нүглийг, эсвээс шинэ бөгөөд үүрдийн гэрээг ямар ч байдлаар, мөн гутамшгийн бүх маягаар зөрчин, мөн хэрэв тэд гэмгүй цусыг урсган аллага үл ^бүйлдэх аваас, тэд анхны амилалтаар урагш гарч ирж, мөн өргөмжлөлдөө орох болно; харин тэд махан биед устгагдах болно, мөн тэд гэтэлгэлийн өдөр хүртэл “Сатаны тамлалд ‘хүргэгдэх болно хэмээн Их Эзэн Бурхан хэлж байна.

27 Дэлхийд ч дэлхийн гадна ч “үл өршөөгдөх Ариун Сүнсний эсрэг ^бдоромжлол нь, та нар гэмгүй цусыг урсгах аллага үйлдэхэд байдаг, мөн миний шинэ бөгөөд үүрдийн гэрээг та нар хүлээж авсны дараа миний үхэлд зөвшөөрөл өгч байгаа хэрэг хэмээн

20б С ба Г 50:26–29;
76:94–95; 84:35–39.
21а су Хууль.
22а Лук 13:24;
2 Ниф. 33:9;
Хил. 3:29–30.
б С ба Г 132:30–31.
в Мат. 7:13–14, 23;
2 Ниф. 9:41;
31:17–21.
23а Иохан 14:2–3.

24а Иохан 17:3.
су Мөнх амьдрал.
б Иохан 3:16–17;
С ба Г 49:5.
25а Мат. 7:13–14;
3 Ниф. 14:13–15.
б су Сүнсний үхэл.
в Иохан 5:43.
26а су Амлалтын
Ариун Сүнс.
б Алма 39:5–6.

в су Чөтгөр.
г С ба Г 82:21; 104:9–10.
27а Мат. 12:31–32;
Евр. 6:4–6;
С ба Г 76:31–35.
су Мөхлийн
хүүхдүүд.
б су Доромжлох,
Доромжлол;
Уучлагдашгүй
нүгэл.

Их Эзэн Бурхан хэлдэг; мөн энэ хуулийг мөрддөггүй тэрээр миний алдар сууд орох нь огт үгүй, харин “яллагдах болно хэмээн Их Эзэн хэлдэг.

28 Би бол Их Эзэн, чиний Бурхан бөлгөө, мөн дэлхий байхаас өмнө надаар болон миний Эцэгээр томилогдсоны адилаар Ариун санваарын хуулиа чамд өгөх болно.

29 “Абрахам бүх зүйлийг хүлээн авсан, юуг ч гэсэн тэрээр илчлэлтээр хийгээд зарлигаар, миний үгээр хүлээн авч, мөн өргөмжлөлдөө орж мөн сэнтийдээ заларч буй хэмээн Их Эзэн хэлж байна.

30 Абрахам өөрийн үр удмын талаар “амлалтыг хүлээн авчээ, мөн түүний хэвлийн үр жимсний талаар—түүний ^бхэвлийгээс гарсан чи, тухайлбал, миний үйлчлэгч Иосеф—тэд дэлхийд байхын хэрээр энэ нь тийм урт удаанаар үргэлжлэх болно; мөн Абрахам болон түүний үр удмын хувьд дэлхийгээс гадна тэд үргэлжлэх ёстой; дэлхийд болон дэлхийгээс гадна аль алинд нь тэд тоо томшгүй ^водод мэт үргэлжлэх ёстой; эсвээс, хэрэв та нар далайн эрэг дэх элсийг тоолохтой адил та нар тэдгээрийг тоолж чадах нь үгүй.

31 Энэ амлалт тэрчлэн та нарынх билээ, учир нь та нар

“Абрахамынх, мөн уг амлалт Абрахамд өгөгдсөн буюу; мөн энэ хуулиар миний Эцэгийн ажлуудын үргэлжлэл байдаг, үүгээр дамжуулан тэрээр өөрийгөө алдаршуулдаг.

32 Явагтун та нар, тиймийн тул, мөн Абрахамын “ажлыг хийгтүн; миний хуулинд орогтун та нар, мөн та нар аврагдах ёстой.

33 Харин хэрэв та нар миний хуулинд эс орох аваас, Абрахамд хийсэн миний Эцэгийн амлалтыг та нар хүлээн авах нь үгүй.

34 Бурхан Абрахамд “зарлиглаж мөн ^вСара ^вХейгарыг Абрахамд эхнэр болгон өгсөн бөлгөө. Мөн тэрээр юуны учир үүнийг хийв? Учир нь гэвэл энэ бол хууль байлаа; мөн Хейгараас олон хүн салбарлан төрсөн болой. Энэ нь, тиймийн тул, бусад зүйлсийн адилаар уг амлалтуудыг гүйцэлдүүлсэн байв.

35 Тиймийн тул, Абрахам буруушаалт дор байсан уу? Үнэнээр би та нарт хэлж байна, Үгүй; учир нь Их Эзэн бибээр үүнийг “зарлигласан билээ.

36 Хүү ^вИсаакаа өргөлд өргөхийг Абрахамд ^взарлигласан байлаа; гэсэн хэдий ч: Чи “хүн алах ёсгүй хэмээн бичигдсэн байв. Гэсэн ч Абрахам татгалзсан нь үгүй, мөн

27в су Ял.

29а су Абрахам.

30а Эхл. 12:1–3; 13:16.

су Абрахам—
Абрахамын үр
удам; Абрахамын
гэрээ.

б 2 Ниф. 3:6–16.

в Эхл. 15:5; 22:17.

31а С ба Г 86:8–11;
110:12.

32а Иохан 8:39;

Алма 5:22–24.

34а Эхл. 16:1–3.

б су Сара.

в Эхл. 25:12–18.

су Хейгар.

35а Иаков 2:24–30.

36а су Исаак.

б Эхл. 22:2–12.

в Ег. 20:13.

энэ нь 'зөв шударга ёс хэмээн түүнд тооцогдсон бөлгөө.

37 Абрахам “татвар эмсийг хүлээж авсан бөлгөө, мөн тэд түүнд хүүхдүүдийг төрүүлсэн болой; мөн энэ нь зөв шударга ёс хэмээн түүнд тооцогдсон бөлгөө, учир нь тэд түүнд өгөгдсөн байлаа, мөн тэрбээр миний хуулийг мөрдсөн болой; Исаакийн адилаар тэрчлэн ^бИаков ч зарлиглагдсанаас өөр зүйлүүд юуг ч үл хийсэн буюу; мөн тэдэнд зарлигласнаас өөр зүйлүүд юуг ч тэд үл хийсний улмаас тэд амлалтуудын дагуу ^вөргөмжлөлдөө орж, тэнгэр элчүүд биш, харин бурхад болж, мөн сэнтийдээ заларч буй.

38 “Давид мөн миний үйлчлэгчид Соломон болон Мосе, тэрчлэн миний бусад олон үйлчлэгч бүтээлтийн эхлэлээс энэ цаг үеийг хүртэл, тэрчлэн ^болон эхнэр хийгээд татвар эмсийг хүлээн авсан бөлгөө, мөн тэд надаас хүлээж аваагүй тэдгээр зүйлүүдийг үл тооцвол, тэд юунд ч нүгэл үйлдээгүй билээ.

39 Давидын эхнэрүүд хийгээд татвар эмс надаас, миний үйлчлэгч Натан болон энэхүү хүчний “түлхүүрүүд тэдэнд байсан бусад бошиг-

логчдын гараар түүнд ^бөгөгдсөн бөлгөө; мөн ^вУриа болон түүний эхнэрийн тохиолдлыг эс тооцвол, тэрээр эдгээр зүйлүүдийн алинд нь ч миний эсрэг нүгэл үйлдээгүй болой; мөн тиймийн тул, тэрээр өргөмжлөлөөсөө унасан билээ, мөн өөрийн хувийг хүлээн авсан буюу; мөн тэрээр тэдгээрийг дэлхийгээс гадна өвлөх нь үгүй, учир нь бибээр тэдгээрийг өөр нэгэнд 'өгсөн буюу хэмээн Их Эзэн хэлж байна.

40 Бибээр Их Эзэн чиний Бурхан билээ, мөн би чамд томилолтыг, мөн бүх зүйлийг ^всэргээхийг өгч байна, үйлчлэгч Иосеф минь. Хүссэнээ асуугтун, мөн энэ нь миний үгийн дагуу чамд өгөгдөх болно.

41 Мөн чи садар самууны талаар асуусан болохоор, үнэнээр, үнэнээр би чамд хэлж байна, хэрэв эр хүн нэг эхнэрийг шинэ бөгөөд үүрдийн гэрээнд хүлээн авбаас, мөн тэр эмэгтэй өөр эрэгтэйтэй хамт байх аваас, мөн ариун тослолтоор түүнд би томилоогүй бол, тэр эмэгтэй садар самууныг үйлдсэн бөгөөд устгагдах болно.

42 Хэрэв тэр эмэгтэй шинэ

36г Иаков 4:5.
су Зөв шударга,
Зөв шударга ёс.

37а ө.х. Өөр эхнэрүүд.

Эхл. 25:5-6.

б Эхл. 30:1-4;

С ба Г 133:55.

су Иаков, Исаакын хүү.

в су Өргөмжлөл;

Хүмүүн, Хүмүүс—
Хүн, Тэнгэрлэг
Эцэгтэй адил болох
боломж.

38а су Давид.

б 1 Сам. 25:42-43;

2 Сам. 5:13;

Хаад. дээд 11:1-3.

39а су Санваарын

түлхүүрүүд.

б 2 Сам. 12:7-8.

в 2 Сам. 11:4, 27; 12:9;

Хаад. дээд 15:5.

су Завхайрал;

Аллага.

г Иер. 8:10.

40а ИС—Т 1:33.

су Сайн мэдээний
сэргээлт.

бөгөөд үүрдийн гэрээнд үл байх аваас, мөн тэрээр өөр эрэгтэйтэй хамт байх аваас, тэрээр садар самууныг “үйлдсэн болой.

43 Мөн хэрэв түүний нөхөр нь өөр эмэгтэйтэй хамт байх аваас, мөн тэрээр “тангараг дор байсан бол, тэрээр уг тангаргаа зөрчиж, мөн садар самууныг үйлдсэн бөлгөө.

44 Мөн хэрэв тэр эмэгтэй садар самууныг үйлдээгүй бол, харин гэм буруугүй бөгөөд андгайгаа зөрчөөгүй, мөн тэрээр үүнийг мэддэг бол, би үүнийг чамд илчлэх болно, миний үйлчлэгч Иосеф, тэгвэл чи миний Ариун Сүнсний хүчээр, түүнийг авч мөн садар самууныг эс үйлдэн харин “үнэнч итгэлтэй байх түүнд тэр эмэгтэйг өгөх хүч чамд байх болно; учир нь тэр эрэгтэй олны дээр захирагч болгогдох болно.

45 Учир нь би бүх зүйлийг “сэргээж, мөн тогтоосон цагт нь бүх зүйлийг та нарт мэдүүлэх уг санваарын ^бтүлхүүрүүд хийгээд хүчийг бибээр чамд хүртгээлээ.

46 Мөн үнэнээр, үнэнээр, би чамд хэлж байна, дэлхий дээр чи юуг ч “лацадлаа гэсэн тэнгэрт лацлагдах болно; мөн дэлхий дээр чи юуг ч миний нэрээр мөн миний үгээр хол-

болоо гэсэн, энэ нь тэнгэрт үүрд мөнхөд холбогдох болно хэмээн Их Эзэн хэлж байна; мөн хэний ч нүглүүдийг чи дэлхий дээр ^буучилна, тэнгэрт мөнхөд уучлагдах болно; мөн хэний ч нүглийг чи дэлхий дээр уучлахгүй хадгална, тэнгэрт мөн уучлагдахгүй хадгалагдах болно.

47 Мөн дахин, үнэнээр би хэлье, чи хэнийг ч адислалаа гэсэн би адислах болно, мөн хэнийг ч чи зүхлээ гэсэн би “зүхэх болно хэмээн Их Эзэн хэлж байна; учир нь бибээр Их Эзэн, чиний Бурхан билээ.

48 Мөн дахин, үнэнээр би чамд хэлж байна, миний үйлчлэгч Иосеф, чи дэлхий дээр юуг ч өглөө гэсэн, мөн миний үгээр, миний хуулийн дагуу чи хэнийг ч хэн нэгэнд өглөө гэсэн, энэ нь зүхлүүдээр бус, харин адислалуудаар мөн миний хүчээр дэлхий дээр зочлогдох болно, мөн дэлхий дээр хийгээд тэнгэрт буруушаалтгүйгээр байх болно хэмээн Их Эзэн хэлж байна.

49 Учир нь бибээр Их Эзэн чиний Бурхан билээ, бас бүр дэлхийн “төгсгөл хүртэл бүх үүрд мөнхөөр дамжин чамтай хамт байх болно, учир нь ^бөргөмжлөлийг чинь би чам дээр үнэнээр “лацдан мөн

42a С ба Г 42:22–26.

43a су Гэрээ; Гэрлэлт, Гэрлэх.

44a су Ариун явдал.

45a Үйлс 3:21;

С ба Г 86:10.

су Сайн мэдээний

сэргээлт.

б су Санваарын түлхүүрүүд.

46a су Лацдах, Лацдалт.

б су Нүглүүдийн ангижрал.

47a Эхл. 12:1–3;

С ба Г 124:93.

49a Мат. 28:20.

б С ба Г 5:22.

су Дуудлага ба

Сонгогдогсод.

в С ба Г 68:12.

чамд зориулж, ‘эцэг Абрахамын чинь хамт Эцэгийнхээ хаант улсад хаан сэнтийг бэлтгэх бөлгөө.

50 Болгоогтун, “золиослолуудыг чинь би харсан билээ, мөн бүх нүглийг чинь өршөөх болно, чамд миний ярьсныг дуулгавартай дагахад хийсэн золиослолуудыг чинь бибээр харсан билээ. Тиймийн тул, явагтун, Абрахам хүү Исаакаараа өргөл өргөх гэснийг ⁶хүлээн авсан шиг, зугтах замыг чинь би чамд бэлтгэх болой.

51 Үнэнээр, би чамд хэлж байна, тэрээр байгаагаараа үлдэж мөн чамд зарлигласан зүйлээс өөртөө санал болгохгүй байхыг чиний эхнэр, чамд миний өгсөн миний гарын үйлчлэгч Эмма Смитэд би зарлиглаж байна; учир нь гэрээ ба золиослоор би та нарын гараас өргөл шаардаж болохын тулд Абрахамын нэгэн адил, та нар бүгд өөрсдийгөө нотлон харуулахаар болгосон билээ би.

52 Мөн миний гарын үйлчлэгч “Эмма Смит миний өмнө ариун журамтай хийгээд цэвэр байгаа миний үйлчлэгч Иосефт өгөгдсөн тэдгээр бүгдийг хүлээн аваг, мөн цэвэр ариун бус боловч, цэвэр ариун хэмээн хэлэх тэд устгагдах болно хэмээн Их Эзэн Бурхан хэлж байна.

53 Учир нь бибээр Их Эзэн, чиний Бурхан билээ, мөн чи миний дуу хоолойг дуулгавартай дагах ёстой, мөн тэрээр олон зүйлийн дээр захирагч болгогдох болно хэмээх зарлигийг би өөрийн үйлчлэгч Иосефт өгсөн болой, учир нь тэрээр цөөн хэдэн зүйлд “итгэлтэй байж чадлаа, мөн үүнээс хойш би түүнийг хүчирхэгжүүлэх болно.

54 Мөн өөр хэнтэй ч биш, миний үйлчлэгч Иосефтой нэгдэн нийлж мөн үнэнч байхыг би өөрийн гарын үйлчлэгч Эмма Смитэд зарлиглаж байна. Харин, хэрэв тэрээр энэ зарлигийг үл дагах аваас, тэрээр устгагдах болно хэмээн Их Эзэн хэлж байна, учир нь бибээр Их Эзэн, чиний Бурхан билээ, мөн хэрэв тэрээр миний хуулийг үл мөрдөх аваас түүнийг устгах болно.

55 Харин хэрэв тэрээр энэ зарлигийг үл мөрдөх аваас, тэгвэл миний үйлчлэгч Иосеф түүний өмнөөс бүх зүйлийг, бүр тэрээр хэлсэнчлэн хийх ёстой, мөн би түүнийг адисалж мөн түүнийг өгсөн үржүүлж мөн энэ дэлхийд түүнд “зуу дахин илүү эцгүүд хийгээд эхчүүдийг, ах дүү хийгээд эгч дүүсийг, өрх гэр хийгээд газар нутаг, эхнэр ба хүүхдүүдийг өгч, мөн мөнхийн дэлхийнүүдэд

49г Эхл. 17:1–8;
2 Ниф. 8:2.
50а су Золиослол.
б Эхл. 22:10–14;

С ба Г 97:8.
52а су Смит, Эмма
Хейл.
53а Мат. 25:21;

С ба Г 52:13.
55а Марк 10:28–31.

⁶мөнх амьдралын титмийг өгөх болно.

56 Мөн дахин, үнэнээр би хэлж байна, миний гарын үйлчлэгч миний үйлчлэгч Иосефын гэм бурууг “уучлаг, мөн тэгвэл тэрээр миний эсрэг үйлдсэн гэм буруудаа өршөөгдөх болно, мөн Их Эзэн, чиний Бурхан бибээр түүнийг адислаж мөн түүнийг өсгөн үржүүлж, мөн зүрх сэтгэлийг нь баясгах болно.

57 Мөн дахин, би хэлье, дайсан ирж, мөн түүнийг устгахгүйн тулд миний үйлчлэгч Иосеф өмч хөрөнгөө гараасаа бүү гаргаг, учир нь Сатан устгахыг “эрэлхийлдэг бөлгөө; учир нь бибээр Их Эзэн, чиний Бурхан билээ, мөн тэрбээр миний үйлчлэгч билээ, мөн болгоогтун, мөн харагтун, чиний эцэг Абрахамтай бүр түүний ⁶өргөмжлөл хийгээд сүр жавхланд би хамт байсны адилаар би чамтай хамт байна.

58 Эдүгээ, “санваарын хуулийг хөндвөл, үүнд хамаарах олон зүйл тэнд буй.

59 Үнэнээр, хэрэв хүн “Аароны нэг адил миний дуу хоолойгоор мөн намайг илгээсэн түүний дуу хоолойгоор миний Эцэгээс дуудагдаж мөн энэ санваарын хүчний ⁶түлхүүрүүдээр би

түүнд хишиг хүртээх аваас, мөн миний хуулийн дагуу мөн миний үгээр тэрбээр миний нэрэнд аливааг хийх аваас, тэрээр нүгэл үл үйлдвээс, мөн түүнийг зөвтгөх болно би.

60 Тиймийн тул, нэг ч хүн миний үйлчлэгч Иосефт бүү халдаг, учир нь би түүнийг зөвтгөх болно, учир нь түүний зөрчлийн учир түүний гараас миний шаардах золиослолыг тэрээр хийх болно хэмээн Их Эзэн, чиний Бурхан хэлж байна.

61 Мөн дахин, санваарын хуулинд хамаарснаар—хэрэв аливаа эр хүн “ариун бүсгүйтэй гэр бүл болж, мөн ⁶өөр нэгэнтэй гэр бүл болохыг хүсч, мөн эхнийх нь зөвшөөрөх аваас, мөн хэрэв мөнөөх эр хоёр дахиа гэрлэх аваас, мөн тэд ариунаараа байх аваас, мөн өөр эрэгтэйтэй андгай тавиагүй байх аваас, тэгвэл тэр эрэгтэй зөвтөгдөх болой; тэд түүнд өгөгдсөн учраас тэрээр садар самууныг үйлдсэн нь үгүй бөлгөө; учир нь өөр нэгэнд биш, харин түүнд өөрт нь харьяалагдах түүнтэй тэрээр садар самууныг үйлдэж үл чадах бөлгөө.

62 Мөн хэрэв энэ хуулиар түүнд арван ариун бүсгүй өгөгдөх аваас, тэрээр садар самууныг үйлдэж үл чадах

55б су Гэр бүл—
Мөнхийн гэр бүл;
Мөнх амьдрал.

56а су Уучлах.

57а Мат. 10:28.

б су Өргөмжлөл.

58а С ба Г 84:19–26.
су Санваартан.

59а Евр. 5:4.

су Аарон,
Мосегийн ах.

б су Санваарын

түлхүүрүүд.

61а су Ариун.

б Албан Тунхаг—1.

су Гэрлэлт,
Гэрлэх—Олон
эхнэр авах ёс.

бөлгөө, учир нь тэд түүнд харъяалагдах буюу, мөн тэд түүнд өгөгдсөн бөлгөө; тиймийн тул тэрээр зөвтгөгдөх болой.

63 Харин хэрэв тэр арван ариун бүсгүйгээс нэг буюу хоёр нь, гэр бүл бололцсоны дараа, өөр эр хүнтэй хамт байх аваас, тэрээр садар самууныг үйлдсэн хэрэг, мөн устгагдах болно, учир нь тэд миний зарлигийн дагуу “өсөн үржиж, мөн дэлхийг дүүргэхийн тулд мөн дэлхийн сууринаас өмнө миний Эцэгээр өгөгдсөн амлалтыг хэрэгжүүлэхийн тулд, мөн мөнхийн дэлхийнүүд дэх тэдний өргөмжлөлийн тулд, тэд хүмүүний бодгалиудыг авчирч болохын тулд түүнд өгөгдсөн бөлгөө, учир нь тэрээр алдаршиж болохын тулд миний Эцэгийн “ажил энд үргэлжилж буй.

64 Мөн дахин, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлж байна, хэрэв энэ хүчний түлхүүрүүдийг атгагч хэн нэгэн эр нэг эхнэртэй байж, мөн тэрээр миний санваарын хуулийг эдгээр зүйлүүдэд хамаарыхынх нь хувьд түүнд заах

аваас, мөн тэгээд тэр эмэгтэй түүнд итгэж мөн туслах ёстой, эс бөгөөс тэр устгагдах болно, учир нь би түүнийг устгах болно, учир нь миний хуулийг хүлээн авч мөн мөрддөг тэд бүгдийн дээр би өөрийн нэрийг тодруулан томсгох болно.

65 Тиймийн тул, хэрэв тэр эмэгтэй энэ хуулийг үл хүлээн авбал, Их Эзэн бибээр түүнд өгөх бүх зүйл юуг ч гэсэн, тэр эрэгтэй хүлээж авах нь надад хууль ёсны байх болно, учир нь тэр эмэгтэй миний үгийн дагуу түүнд итгэж мөн туслаагүй болой; мөн тэгэхэд тэр эмэгтэй зөрчил гаргагч болно, мөн тэр эрэгтэй Хейгарыг эхнэр болгон ав хэмээн намайг зарлиглахад уг хуулийн дагуу Абрахамд тусалсан Сарогийн хуулиас чөлөөлөгдөх болой.

66 Мөн эдүгээ, энэ хуулинд хамааруулан, үнэнээр, үнэнээр би чамд хэлнэ, үүнээс хойш улам ихийг би чамд илчлэх болно, тиймийн тулд энэ удаад энэ нь хангалттай байг. Болгоогтун, бибээр Альфа ба Омега болой. Амен.

ХЭСЭГ 133

1831 оны арваннэгдүгээр сарын 3-нд Огайогийн Хайрамд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгөгдсөн илчлэлт оршвой (History of the Church, 1:229–234). Энэ илчлэлтийн өмнөх үг болгон Бошиглогч бичихдээ, “Дэлхийн оршин суугчдад Сайн мэдээг номлох мөн цугларалттай холбогдуулан ахлагчид мэдэхийг хүсч буй олон зүйл энэ цаг үед байлаа, мөн үнэн гэрлээр аллахын тулд, мөн дээрээс зааварлагдахын тулд, 1831 оны арваннэгдүгээр сарын 3-нд би Их

Эзэнээс асууж тийнхүү дараах чухал илчлэлтийг хүлээн авсан” хэмээжээ (History of the Church, 1:229). Энэ хэсэг Сургаал ба Гэрээ номонд хавсралт болон анх удаа нэмэгдэж орсон бөгөөд хожим нь уг хэсэгт дугаар олгожээ.

1–6, Гэгээнтнүүд Хоёрдахь Ирэлтэд бэлтгэхээр зарлиг болгогдов; 7–16, Бүх хүмүүн Вавилоноос зугтаж, Сионд ирэхээр, мөн Их Эзэний агуу их өдөрт бэлтгэхээр зарлиг болгогдов; 17–35, Тэрбээр Сионы Уулан дээр зогсох болно, тивүүд нэг газар болно, мөн Израилын алдагдсан овгууд эргэж ирэх болно; 36–40, Сайн мэдээ бүх дэлхийд номлогдохын тулд Иосеф Смитээр дамжин сэргээгдэв; 41–51, Их Эзэн ёс бусчууд дээр өс авалтад доош бууж ирэх болно; 52–56, Энэ нь түүний гэтэлгэгдэгсдийн жил байх болно; 57–74, Гэгээнтнүүдийн аврал мөн ёс бусчуудын устгалын тулд сайн мэдээ урагш илгээгдэх ёстой.

АНХААРАГТУН, Ай миний Асүмийн хүмүүс, мөн өөрсдийнхөө талаарх Их Эзэний үгийг анхаарагтун хэмээн Их Эзэн, та нарын Бурхан хэлж байна —

2 Өөрийнхөө ариун сүмд гэнэт “ирэх Их Эзэн бөлгөө; ⁶шүүлтийн тулд дэлхий дээр зүхэлтэйгээр доош бууж ирэх Их Эзэн; тийм ээ, Бурханыг

мартсан бүх үндэстэн дээр, мөн та нарын дундах бурханлиг бус бүгд дээр бөлгөө, 3 Учир нь тэрбээр бүх үндэстний нүдэн дээр ариун мутраа “ил гаргах болно, мөн дэлхийн бүх хязгаар Бурханыхаа ⁶авралыг харах болно.

4 Иймийн тул, бэлтгэцгээ та нар, бэлтгэцгээ та нар; Ай миний хүмүүс; өөрсдийгөө ариусгагтун; Сионы нутагт хамтдаа цуглагтун, Ай миний сүмийн хүмүүс та нар, үлдэхээр зарлиг болгогдоогүй та бүгд.

5 “Вавилоноос гарагтун та нар. Их Эзэний савуудыг авч явахуйцаар ⁶цэвэр ариун байгтун та нар.

6 Өөрсдийн онцгой ариун хуралдайг дуудагтун мөн бие биедээ олонтаа “яригтун. Мөн хүн болгон Их Эзэний нэрийг дуудаг.

7 Тийм ээ, үнэнээр би дахин та нарт хэлж байна, Их Эзэний дуу хоолой та нарт байх тэрхүү цаг ирлээ: Вавилоноос гарагтун та нар; үндэстнүүдийн дундаас, дэлхийн “дөр-

133 2a Малах. 3:1;
С ба Г 36:8.
б С ба Г 1:36.
су Есүс Христ—
Шүүгч.
3a Иса. 52:10.
б Иса. 12:2; 52:10.
су Гэтэлгэлийн

төлөвлөгөө; Аврал.
5a Алма 5:57;
С ба Г 1:16.
су Бабел, Вавилон;
Дэлхийнх.
б 2 Тим. 2:21;
3 Ниф. 20:41;
С ба Г 38:42.

су Цэвэр ариун,
Цэвэр ариун
байдал.
6a Малах. 3:16–18.
7a Зех. 2:6–7;
Марк 13:27.

вөн зүгээс, тэнгэрийн бүх хязгаараас ^бцугларцгаа та нар.

8 Миний сүмийн ахлагчдыг алс холын үндэстнүүд уруу; далайн “арлууд уруу урагш илгээгтүн; гадаадын нутгууд уруу ^билгээгтүн; бүх үндэстнийг, эхлээд “харийнханыг мөн дараа нь ‘иудейчүүдийг дуудагтун.

9 Мөн болгоогтун, мөн харагтун, энэ нь тэдний хашгиралт мөн бүх хүмүүст хандсан Их Эзэний дуу хоолой байх болно: миний хүмүүсийн хил хязгаарууд өргөжихийн тулд, мөн үүний “гадаснууд хүчирхэгжихийн тулд, мөн ^бСион эргэн тойрныхоо бүс нутгууд уруу урагш явж болохын тулд Сионы нутаг уруу явцгаагтун та нар.

10 Тийм ээ, тэрхүү тунхаглал бүх хүмүүсийн дунд урагш одог: “Хүргэн Хүүг угтахаар сэрж мөн босон мөн урагш одогтун, Хүргэн Хүү айсуу; түүнийг угтахаар гарагтун та нар. Их Эзэний ^багуу их өдөрт өөрсдийгөө бэлтгэгтүн.

11 “Сэрэмжтэй байгтун, тиймийн тул, учир нь тэр өдрийг

ч мөн тэр цагийг ч та нар ^бмэдэх нь үгүй.

12 Тиймийн тул, харийнханы “дундах тэд ^бСион уруу зугтаг.

13 Мөн “Иудейнх болох тэд ^бИерусалим уруу, Их Эзэний ^бөргөөний ‘уулсууд уруу зугтаг.

14 Үндэстнүүдийн дундаас, бүр Вавилоноос, сүнсний Вавилон болох ёс бусын дундаас гарч явцгаагтун та нар.

15 Гэвч үнэнээр ийн Их Эзэн хэлж байна, та нарын зугталт “яаруу тэвдүү бүү байг, харин бүх зүйл та нарын өмнө бэлтгэгдэг; мөн явах тэрбээр, гэнэтийн устгал түүн дээр ирэхгүйн тулд тэрээр ^бэргэж бүү хараг.

16 Анхаарагтун, мөн сонс, Ай дэлхийн оршин суугчид та нар. Миний сүмийн ахлагчид хамтдаа та нар “дуулж, мөн Их Эзэний дуу хоолойг сонсогтун; учир нь тэрбээр бүх хүмүүсийг дуудаж, мөн тэрбээр газар бүрийн бүх хүмүүнд ^бнаманчлахыг зарлигладаг бөлгөө.

17 Учрыг болгоогтун: Их Эзэний замыг бэлтгэгтүн, мөн түүний замыг “шулуун

7б С ба Г 29:8.
су Израил—
Израилын
цугларалт.

8а Иса. 11:11;
1 Ниф. 22:4;
2 Ниф. 10:8, 20.

б су Номлолын
ажил.

в су Харийнхан.

г су Иудейчүүд.

9а су Сион.
б Иса. 54:2.

су Гадас.
10а Мат. 25:6;
С ба Г 33:17–18;
45:54–59.

су Хүргэн Хүү.
б С ба Г 1:12–14.

11а Марк 13:32–37;
ИС—А 1:46, 48.

б С ба Г 49:7.

12а С ба Г 38:31, 42.

б су Сион.

13а су Иудей.
б су Иерусалим.

в Дуул. 122:1–9.

г Иса. 2:1–3;

Езек. 38:8.

15а Иса. 52:10–12;

С ба Г 58:56.

б Эхл. 19:17, 26;

Лук 9:62.

16а С ба Г 1:1–6.

б су Наманчлах,

Наманчлал.

17а Иса. 40:3–5.

болгогтун та нар, учир нь түүний ^бирэлтийн цаг ойрхон байна хэмээн өгүүлж тэнгэрийн дундуур хашгирах тэнгэр элчийг Их Эзэн урагш ^аилгээсэн бөлгөө.

18 Түүний Эцэгийн нэр тэргүүн дээр нь бичээстэй “нэг зуун дөчин дөрвөн мянгын хамт ^бХургыг ^аСионы Уулан дээр зогсож байхад буюу.

19 Иймийн тул, “Хүргэн Хүүгийн ^бирэлтэд бэлтгэгтүн та нар; түүнийг угтахаар гарагтун та нар, гарагтун та нар.

20 Учрыг болгоогтун, тэрээр Оливетын уулан дээр, мөн сүр хүчит, бүр агуу гүн далай дээр, мөн далайн арлууд дээр, мөн Сионы газар нутаг дээр “зогсох болно.

21 Мөн тэрбээр “Сионоос дуу хоолойгоо ^бсонордуулж, мөн тэрбээр Иерусалимаас ярих болно, мөн түүний дуу хоолой бүх хүмүүсийн дунд сонсогдох болно;

22 Мөн энэ нь их усны “дуу хоолой мэт, мөн уулсыг доош ^бнураах, агуу их “аянгын дуу хоолой мэт байх болно, мөн тал хөндийнүүд үгүй болох болно.

23 Тэрбээр агуу гүнд зарлиглах болно, мөн энэ нь умардын орнууд уруу гэдрэг, мөн нэг газар болсон байх “арлууд уруу туугдах болно;

24 Мөн “Иерусалимын нутаг мөн Сионы нутаг, өөрсдийнхөө газарт гэдрэг буцаагдах болно, мөн дэлхий ^бхуваагдахынхаа өмнө тэрхүү өдрүүдэд байсантайгаа адил болох болно.

25 Мөн Их Эзэн, бүр Аврагч өөрийн хүмүүсийн дунд зогсох болно, мөн бүх махан бодь дээр “хаанчлах болно.

26 Мөн “умардын орнуудахь тэд Их Эзэний өмнө дурсамжид ирэх болно; мөн тэдний бошиглогчид түүний дуу хоолойг сонсох болно, мөн өөрсдийгөө цаашид үлдээхээ болино; мөн тэд хаднуудыг цохих болно, мөн тэдний байгаа газарт мөс доош гулсан урсах болно.

27 Мөн тэрхүү агуу гүний дунд “дардан зам баригдах болно.

28 Дайснууд нь тэдэнд идэш болох болно,

29 Мөн “үржил шимгүй цөллүүдэд амьд усан цөөрмүүд

176 Малах. 3:1.

в С ба Г 13:1; 27:7–8; 88:92.

18a Илч. 7:1–4.

б Илч. 14:1.

су Бурханы Хурга.

в С ба Г 84:2.

19a су Хүргэн Хүү.

б Мат. 25:1–13;

С ба Г 33:17–18; 88:92.

су Есүс Христийн Хоёр дахь Ирэлт.

20a Зех. 14:4;

С ба Г 45:48–53.

21a Иса. 2:2–4.

б Иоел 3:16; Амос 1:2.

22a Езек. 43:2; Илч. 1:15;

С ба Г 110:3.

б Шүүгч. 5:5; Иса.

40:4; 64:1; Илч. 16:20;

С ба Г 49:23; 109:74.

в Дуул. 77:18;

Илч. 14:2.

23a Илч. 6:14.

24a су Иерусалим.

б Эхл. 10:25.

су Газар дэлхий—

Газар дэлхийн хуваагдал.

25a су Есүс Христ—

Христийн Мянган жилийн хаанчлал.

26a Иер. 16:14–15;

С ба Г 110:11.

су Израил—

Израилын алдагдсан арван овог.

27a Иса. 11:15–16;

2 Ниф. 21:16.

29a Иса. 35:6–7.

гарч ирэх болно; мөн хатсан газар цаашид ангаж гандсан газар байхаа болино.

30 Мөн тэд баялаг сан хөмрөгүүдээ миний үйлчлэгчид, “Ефраимын хүүхдүүдэд авчрах болно.

31 Мөн үүрдийн “дов толгодын хязгаарууд тэдний байгаа газарт дагжин чичрэх болно.

32 Мөн тэнд тэд доош унаж бас бүр Сионд, Их Эзэний үйлчлэгчдийн, бүр Ефраимын хүүхдүүдийн гараар сүр жавхлангаар титэмлэгдэх болно.

33 Мөн тэд үүрдийн баяслын “дуунуудаар дүүргэгдэх болно.

34 Болгоогтун, энэ бол Израилын “овгууд дээрх үүрдийн Бурханы адислал түүнчлэн “Ефраим хийгээд түүний нөхдийн тэргүүн дээрх илүү баялаг адислал бөлгөө.

35 Мөн тэд тэрчлэн, түүний дэргэд өдөр хийгээд шөнө, үүрд мөн мөнхөд оршихын тулд Их Эзэний өмнө “цэвэр ариун байдалд ариусгагдсан, өвчлөлийн дараах Иудейн “өвгийнх болой.

36 Мөн эдүгээ, үнэнээр Их Эзэн хэлж байна, эдгээр зүйлүүд та нарын дунд

мэдэгдэж болохын тулд, Ай дэлхийн оршин суугчид, тэнгэрийн дундуур нисэгч өөрийн “тэнгэр элчийг үүрдийн “сайн мэдээтэйгээр би урагш илгээсэн билээ, тэрээр зарим хүмүүс дээр хүрч ирсэн мөн хүмүүнд үүнийг даатгасан мөн дэлхийд оршин суудаг олон дээр хүрч ирнэ.

37 Мөн энэ “сайн мэдээ “бүх үндэстэн, мөн ястан мөн хэлтэн мөн хүмүүст “номлогдох болно.

38 Мөн Бурханы үйлчлэгчид: Бурханаас эмээж мөн түүнд алдар сууг өргөгтүн, учир нь түүний шүүлтийн цаг айсуй хэмээн чанга дуу хоолойгоор өгүүлж урагш одох болно;

39 Мөн тэнгэр, бас дэлхий, мөн далай тэнгис, бас усан оргилууруудыг бий болгосон түүнийг “бишрэн шүтэгтүн —

40 Их Эзэний нэрийг өдөр ба шөнөөр дуудан: Ай та тэнгэрийг “цуу татаж чадах бөлгөө, таны дэргэд уулс доош гулсан бууж болохын тулд та доошлон ирж болох буюу хэмээн хэлэх болой;

41 Мөн энэ нь тэдний тэргүүн дээр хариулагдах болно; учир нь Их Эзэний оршихуй нь шатаадаг гал хайлуулагч

30a Зех. 10:7–12.
су Ефраим—
Ефраимын овог.
31a Эхл. 49:26.
33a Иса. 35:10; 51:11;
С ба Г 66:11.
34a су Израил—
Израилын
арванхоёр овог.

б Эхл. 48:14–20;
Шаст. дээд 5:1–2;
Ифер 13:7–10.
35a су Цэвэр ариун
байдал.
б су Иуда—
Иудагийн овог.
36a Илч. 14:6–7;
С ба Г 20:5–12.

б су Сайн мэдээний
сэргээлт.
37a су Сайн мэдээ.
б С ба Г 42:58.
в су Номлолын
ажил; Номлох.
39a су Шүтэн бишрэх.
40a Иса. 64:1–2.

лугаа адил, мөн усыг “буцалгахад хүргэх түймрийн гал лугаа адил байх болно.

42 Ай Их Эзэн минь, та өөрийн нэрийг дайснууддаа мэдүүлэхийн тулд доошоо бууж ирэх болно, мөн бүх үндэстнүүд таны оршихуйд дагжин чичрэх болно —

43 Тэдний хүсэн хүлээдэггүй зүйлүүдийг, аюумшигт зүйлүүдийг таныг үйлдэхэд буюу;

44 Тийм ээ, таныг доош бууж ирэхэд, таны оршихуйд уулс доош гулсах болно, мөн баясдаг хийгээд зөв шударгыг үйлдэж мөн таны замуудаар таныг дурсдаг түүнтэй та “уулзах болно.

45 Учир нь дэлхийн эхлэлээс хойш хүмүүн сонссон нь үгүй, мөн чихээр хүлээн авсан нь үгүй, мөн аль ч нүд харсан нь үгүй, Ай Бурхан минь, өөрөөсөө гадна, таныг “хүлээдэг түүний төлөө таны ⁶бэлтгэсэн зүйлүүд хичнээн агуу билээ.

46 Мөн ийн хэлэгдэх болно: Будагдсан өмсгөлтэйгөөр тэнгэр дэх Бурханаас доош буун “ирэгч; тийм ээ, үл мэдэгдэх биеүдээс түүний алдар суут гадаад төрхөөр хувцасласан, хүчин чадлынхаа агуу ихэд аялагч, энэ чинь ⁶хэн бэ?

47 Мөн тэрбээр: Зөв шударгад ярьдаг, аврах хүчирхэг

нэгэн би билээ хэмээн хэлэх болно.

48 Мөн Их Эзэн гаднах төрхөөрөө “улаан байх болно, мөн түүний өмсгөлүүд дарс шахагч түүнтэй адил байх болно.

49 Мөн түүний оршихуйн алдар суу нь, “нар ичингүйрч нүүрээ нуун, мөн сар гэрлээ буцаан авч, мөн одод байрнаасаа шидэгдмээр тийм агуу байх болно.

50 Мөн: дарс шахагчийг би ганцаараа няц “гишгэлээ, мөн бүх хүмүүс дээр шүүлтийг авчрав; мөн надтай хамт хэн ч байсангүй гэх түүний дуу хоолой сонсогдох болно;

51 Би тэднийг хилэгнэлдээ дэвсэллээ, мөн уурандаа би тэдэн дээгүүр алхаллаа, мөн тэдний цус өмсгөлүүд дээр минь “үсрэв, мөн миний бүх хувцас улаанаар будагдав; учир нь энэ бол миний зүрх сэтгэлд байсан өс хонзонгийн өдөр байв.

52 Мөн эдүгээ миний гэтэлгэгдэгсдийн жил айсуу; мөн тэд Их Эзэнийхээ хайрын нинжин сэтгэлийг, мөн түүний нигүүлслийн дагуу, мөн түүний хайрын нинжин сэтгэлийн дагуу өөрсөд дээр нь түүний хүртээсэн тэр бүгдийг үүрд мөн мөнхөд дурдах болно.

53 Тэдний бүх “зовлон зүд-

41a Иов 41:31.

44a 1 Тес. 4:15–18.

45a Сол. дуул. 3:25;

2 Ниф. 6:7, 13.

б Иса. 64:4; 1 Кор. 2:9.

46a су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

б Иса. 63:1–2.

48a Эхл. 49:11–12;

Лук 22:44;

Илч. 19:11–15;

исо, Илч. 19:15;

Мозая 3:7;

С ба Г 19:18.

49a Иса. 13:10; 24:23;

С ба Г 45:42; 88:87.

50a Иса. 63:2–3;

С ба Г 76:107; 88:106.

51a Лев. 8:30.

53a Иса. 63:4–9.

гүүрүүдэд тэрээр зовж зүдэрсэн билээ. Мөн түүний дэргэдэх тэнгэр элч тэднийг аврав; мөн өөрийн ^бхайранд, мөн өөрийн харамсалд, тэрбээр тэднийг ^ггэтэлгэв, мөн эрт дээр үеийн бүх өдрүүдэд тэднийг тээн мөн авч явсан бөлгөө;

54 Тийм ээ, мөн тэрчлэн, “Енох, мөн түүнтэй хамт байсан тэд; түүний өмнө байсан бошиглогчид; мөн тэрчлэн ^бНоа, мөн түүний өмнө байсан тэд; мөн тэрчлэн ^вМоше, мөн түүний өмнө байсан тэд буюу;

55 Мөн Мосегоос Елиаг хүртэл, мөн Елиагаас “амилалтад нь Христтэй хамт байсан Иоханыг хүртэл, мөн ариун төлөөлөгчид, Абрахам, Исаак, мөн Иаковтай хамт Хурганы дэргэд байх болно.

56 Мөн “гэгээнтнүүдийн ^ббулшнууд ^внээгдэх болно; мөн тэд урагш гарч ирэн мөн түүнийг ^вСионы Уулан дээр, мөн ариун хот ^вШинэ Иерусалимд зогсч байхад нь Хурганы ^вбаруун талд зогсох болно; мөн тэд ^вХурганы тухай ^ждууг өдөр мөн шөнө, үүрд мөн мөнхөд дуулах болно.

57 Мөн энэхүү шалтгааны учир, хүмүүн, илчлэгдсэн “алдар суунуудыг хүртэгчид болгогдож болохын тулд, Их Эзэн өөрийн ^бсайн мэдээний бүрэн байдлыг, өөрийн үүрдийн гэрээг эгэл жирийн хийгээд энгийн байдлаар тайлбарлан, урагш илгээсэн бөлгөө—

58 Дэлхийд тохиох тэрхүү зүйлүүдэд сул доройчуудыг бэлтгэхийн тулд, мөн “сул доройчууд мэргэдийг даруусагахад, мөн ^ббага нэг нь хүчирхэг үндэстэн болж, мөн ^вхоёр нь өөрсдийн хэдэн арван мянгыг зугтаалтад тавих тэрхүү өдөрт Их Эзэний заараалын тулд буюу.

59 Мөн дэлхийн сул зүйлүүдээр, Сүнснийхээ хүчээр Их Эзэн үндэстнүүдийг “цохих болно.

60 Мөн энэхүү шалтгааны учир эдгээр зарлигууд өгөгдсөн билээ; Тэдэнд өгөгдсөн тэрхүү өдөр дэлхийд эдгээрийг мэдүүлэхгүй байхыг тэдэнд зарлиг болгосон байв, харин эдүгээ “бүх махан бодийн төлөө ^бурагш одох ёстой—

61 Мөн энэ нь бүх махан бодийг захирдаг Их Эзэний

53б су Энэрэл.
в су Гэтэлгэх,
Гэтэлгэгдэх,
Гэтэлгэл.

54а су Енох.
б су Ноа, Библийн
патриарх.
в су Моше.

55а су Амилуулалт.

56а су Гэгээнтэн.
б С ба Г 29:13.

в С ба Г 45:45–46;
88:96–97.
г Иса. 24:23; Илч. 14:1;
С ба Г 76:66; 84:2,
98–102.
д су Шинэ
Иерусалим.
е Мат. 25:33–34.
ё су Бурханы Хурга.
ж Илч. 15:3;
С ба Г 84:98–102.

57а су Алдар суугийн
зэрэглэлүүд.
б су Сайн мэдээ.
58а Мат. 11:25;
1 Кор. 1:27;
Алма 32:23; 37:6–7.
б Иса. 60:22.
в Дэд хууль 32:29–30.
59а Мика 4:11–13.
60а С ба Г 1:2.
б С ба Г 104:58–59.

оюун хийгээд тааллын дагуу бөлгөө.

62 Мөн “наманчилдаг хийгээд Их Эзэний өмнө өөрийгөө “ариусгадаг түүнд “мөнх амьдрал өгөгдөх болно.

63 Мөн Их Эзэний дуу хоолойг “анхаардаггүй тэнд, тэд хүмүүсийн дундаас “тусгаарлагдах ёстой хэмээн бошиглогч Мосегоор бичигдсэн нь гүйцэлдэх болно.

64 Мөн тэрчлэн бошиглогч “Малахиагаар дамжуулан: Учир нь, болгоогтун, мөн зуух мэт “шатаах тэр “өдөр ирж, мөн бүх бардамнагчид, тийм ээ, ёс бусаар үйлддэг тэд бүгд талбайд хаягдсан сүрэл лугаа адил болох болно, мөн ирэх тэр өдөр тэднийг шатаах болно, энэ нь тэдний үндсийг ч, мөчрийг ч эс үлдээх болно хэмээн Түмний Их Эзэн хэлж байна.

65 Иймийн тул, энэ нь тэндэнд өгөх Их Эзэний хариу байх болно:

66 Би өөрийнхөндөө ирсэн тэр өдөр, та нарын дундах хэн нь ч намайг “хүлээн авсангүй, мөн та нар хөөгдсөн байлаа.

67 Намайг дахин дуудахад,

та нараас хариулах хэн ч байсангүй; харин миний “мутар, мөн миний чөлөөлөх “хүч ч, миний гэтэлгэж чадаагүй тэд бүгдэд богиносгогдсон нь үгүй байв.

68 Болгоогтун, зэмлэлдээ далай тэнгисийг “хатаана би. Гол мөрнүүдийг аглаг буйд болгоно би; тэдгээрийн загас өмхийрч, цангасандаа үхнэ.

69 Тэнгэрийг хараар өвч бүрхэж, мөн бүрээсийг нь шуудайгаар хийх болно би.

70 Мөн “энэ нь та нарт миний гараас байх болно— та нар уй гашуутайгаар доош унах болно.

71 Болгоогтун, мөн харагтун, тэнд та нарыг чөлөөлөх хэн ч үгүй болой; учир нь би тэнгэрээс та нарыг дуудахад, та нар миний дуу хоолойг дуулгавартай дагаагүй билээ; та нар миний үйлчлэгчдэд итгээгүй билээ, мөн тэд та нар уруу “илгээгдэхэд та нар тэднийг хүлээж аваагүй билээ.

72 Иймийн тул, тэд гэрчлэлийг “лацдаж мөн хуулийг холбосон билээ, мөн та нар харанхуйд хүргэгдсэн буюу.

73 “Уйлах мөн гаслах, мөн

62a су Наманчлах,

Наманчлал.

б С ба Г 88:74.

су Ариусгал.

в су Мөнх амьдрал.

63a су Сонсох.

б Үйлс 3:22–23;

1 Ниф. 22:20–21;

3 Ниф. 20:23; 21:11;

С ба Г 1:14;

ИС—Т 1:40.

64a Малах. 4:1.

су Малахи.

б Иса. 66:15–16;

1 Ниф. 22:15;

3 Ниф. 25:1;

С ба Г 29:9; 64:24.

су Дэлхий—

Дэлхийн

цэвэршилт.

в ИС—Т 1:36–37.

66a Иохан 1:11.

67a 2 Ниф. 28:32.

б Иса. 50:2;

2 Ниф. 7:2.

68a Ег. 14:21;

Иош. 3:14–17.

70a Иса. 50:11.

71a Шаст. дэд 36:15–16;

Иер. 44:4–5.

72a Иса. 8:16–20.

73a Мат. 8:11–12;

Лук 13:28;

С ба Г 19:5.

су Сүнсний

харанхуй; Там.

шүдээ хавирах нь буй гадаад харанхуй уруу тэд очих болно.

74 Их Эзэн, та нарын Бурхан үүнийг ярьсныг болгооно уу. Амен.

ХЭСЭГ 134

1835 оны наймдугаар сарын 17-нд Огайогийн Көртландад Сүмийн ерөнхий чуулган дээр нэгдмэл санал өгөлтөөр батлагдсан засгийн газрууд болон хуулиудад итгэх тухай тунхаг оршвой (History of the Church, 2:247–249). Уг үйл явдал нь Сургаал ба Гэрээний анхны хэвлэлийн төлөвлөж буй агуулгыг авч хэлэлцэхээр хамтдаа цугласан Сүмийн удирдагчдын цугларалт байлаа. Тэр үед уг тунхаг дараах өмнөх үгтэй байв: Дэлхийн засгийн газрууд хийгээд хуулиудад нийтэд нь итгэх бидний итгэл буруу тайлбарлагдах буюу буруу ойлгогдохгүй байж болохын тулд энэ ботийн төгсгөлд мөн уг зүйлийн талаарх өөрсдийн санал бодлыг өнөө үед холбогдуулан танилцуулах нь зүйтэй хэмээн үзэв (History of the Church, 2:247).

1–4, Ухамсар хийгээд шүтэн бишрэх эрх чөлөөг засгийн газрууд хамгаалах ёстой; 5–8, Бүх хүмүүс засгийн газруудаа дэмжиж, мөн хуулийг дээдэлж мөн батлан хамгаалах үүрэгтэй байх ёстой; 9–10, Шашины нийгэмлэгүүд иргэний хүчийг ашиглах ёсгүй; 11–12, Өөрсдийгөө болон өмч хөрөнгөө хамгаалахад хүмүүс зөвтгөгдөх бөлгөө.

ЗАСГИЙН газрууд хүмүүний ашиг тусын тулд Бурханаас үндэслэн байгуулагдсан гэдэгт бид итгэдэг; мөн нийгмийн сайн сайхан хийгээд аюулгүй байдлын төлөө хуулиуд боловсруулах хийгээд тэдгээрийг хэрэглэхийн аль алинтай нь холбогдуулан тэрээр хүмүүнийг ажил үйлсийнхээ төлөө ^бха-

риуцлага хүлээлгэхээр болгодог билээ.

2 Ийм хуулиуд боловсруулж мөрдөн мөн зөрчихгүй, тэрчлэн “ухамсрын ^бчөлөөт байдал, өмчийн эрх хийгээд хяналт, мөн амь насаа ^вхамгаалах явдлыг хувь хүн болгонд хангаж өгөхгүйгээр засгийн газар энх тайванд оршиж чадахгүй гэдэгт бид итгэдэг.

3 Мөн уг хуулиудыг албадан сахиулахын тулд бүх засгийн газарт иргэний “ажилтнууд хийгээд төрийн албан хаагчид зайлшгүй шаардлагатай гэдэгт бид итгэдэг; мөн эдгээр хуулийг албан тушаалтнууд тэгш эрх хийгээд шударга ёсонд хэрэглэхийг эрэлхийлэх ёстой бөгөөд бүгд найрамдах улсын хүмүүсийн,

134 1а С ба Г 98:4–7; ИТ 1:12. б су Хариуцах,

Хариуцлага, Хариуцлагатай. 2а су Ухамсар.

б су Сонгох эрх. в С ба Г 42:18–19. 3а С ба Г 98:8–10.

эсвээс бүрэн эрхийн дуу хоолойгоор дэмжиж гэдэг ёстой.

4 Шашин нь Бурханаас үндэслэгдэн бий болсон гэдэгт, мөн хүмүүс түүнд, гагцхүү түүнд, үүнийг шүтсэний төлөө хариуцлага хүлээдэг гэдэгт бид итгэдэг, хэрэв тэдний шашны санал бодлууд тэднийг бусдын эрх хийгээд эрх чөлөөнд халдахад тэднийг эс өдөөх аваас буюу; гэвч хүмүүний хууль нь хүмүүний ухамсрыг тогтоох “шүтлэгийн дүрмүүдийг тодорхойлоход хөндлөнгөөс оролцох, мөн зориулах зүйлийнх нь хэлбэрүүдийг олон нийт буюу хувь хүнд тулган хүлээлгэх эрхтэй байна гэдэгт бид итгэдэггүй; иргэний шүүгчид гэмт хэргийг хазаарлан тогтоох ёстой боловч ухамсрыг хэзээ ч хянах ёсгүй; гэмийг цээрлүүлэх боловч бодгалийн эрх чөлөөг хэзээ ч нухчин дарах ёсгүй.

5 Бүх хүмүүн өөрсдийн харьяалагддаг холбогдох засгийн газруудыг дэмжиж мөн тулах үүрэгтэй байхын сацуу, өөрсдийн зүй ёсны хийгээд салшгүй эрхүүдийг ийм засгийн газруудаар хамгаалуулах ёстой; ийнхүү хамгаалагдсан иргэн бүр “үймээн самуунд өдөөн хатгагдах хийгээд бослого тэмцэлд нийцэшгүй бөгөөд зохих ёсоор шийтгэгддэг байх ёстой; мөн бүх засгийн газрууд шүүлтүүдийнхээ дагуу олон нийтийн ашиг сонирхлыг дээд

зэргээр хангахад ийм хуулиудыг хэрэгжүүлэх эрхтэй; гэсэн хэдий ч, үүний сацуу, ухамсрын ариун нандин эрх чөлөөг дээдлэх учиртай.

6 Хүн бүр өөрийнхөө албан тушаалд, гэм зэмгүй хүмүүсийг хамгаалах хийгээд гэмтнүүдийг цээрлүүлэхийн тулд захирагчид болон шүүгчид ч хүндэтгэгддэг байх ёстой гэдэгт бид итгэдэг, мөн бүх хүмүүн “хуулиудыг дээдлэн мөн хүндэтгэх үүрэгтэй, тэдгээргүйгээр энх амгалан хийгээд эе эв нь эмх замбараагүй явдал хийгээд аллагаар түрэгдэх болно; бидний ашиг сонирхлуудыг хувь хүмүүсийн хувьд хийгээд улс үндэстнүүдийн хувьд, хүн болон хүний хооронд зохицуулах зорилгыг илэрхийлэхийн тулд хүмүүний хуулиуд үндэслэгдэн бий болдог билээ; мөн тэнгэрээс өгөгддөг бурханлиг хуулиуд, сүнсний зүйлүүдийн дүрмүүд, итгэл болон шүтлэг аль алинд нь хүмүүнээр өөрийг нь Бий Болгогчид хариулагдахаар тодорхойлогддог гэдэгт бид итгэдэг.

7 Захирагчид, муж улсууд мөн засгийн газрууд шашны итгэлээ чөлөөтэйгөөр хөгжүүлэх явдлыг бүх иргэдийн хувьд хамгаалах хуулиудыг боловсруулж мөрдөх эрхтэй мөн үүрэгтэй бөлгөө, харин энэ онцгой боломжийг нь иргэдээсээ хасах буюу тэдэнд өөрсдийнхөө санал бодлыг

хууль бусаар тулгах нь шударга ёсон дахь эрх хэмээн бид итгэдэггүй, хүндэтгэл ба дээдлэл нь хуулиудад болон шашны ийм санаа бодлуудад харуулагдсанаар, өдөөн хатгалга хийгээд хуйвалдааныг яагаад ч зөвтгөх учиргүй.

8 Гэмт хэргийг өөгшүүлэх нь, уг хэргийн хохирлын шинж чанарын дагуу “шийтгэгддэг байх ёстой; аллага, сүрдүүлэг, дээрэм, хулгай мөн нийтийн амар амгалан байдлыг бүх талаар алдагдуулах нь хүмүүний дундах тэдний хилэнцэт хандлага хийгээд тэдний гэмт хэргийн байдлын дагуу, тухайн гэмт хэргийн талаарх засгийн газрын хуулиудаар шийтгэгддэг байх ёстой; мөн олон нийтийн энх амгалан хийгээд амар тайван байдлын төлөө бүх хүмүүн, сайн хуулиудын эсрэг хэрэгтнүүдэд шийтгэлийг авчрахад урагш алхаж мөн өөрсдийн чадал боломжийг ашиглах ёстой гэдэгт бид итгэдэг.

9 Шашны нөлөөг иргэний засгийн газартай хольж хутган, үүгээр шашны нэг нийгэмлэг урамшуулан дэмжигддэг бөгөөд нөгөөгийнх нь сүнслэг онцгой боломжуудад саад тотгор учруулж, мөн иргэдийн хувьд гишүүдийнх нь хувь хүний эрхүүдийг үгүйсгэх нь шударга гэдэгт бид итгэдэггүй.

10 Шашны бүх нийгэмлэг

ийм нийгэмлэгүүдийн дүрмүүд хийгээд журмуудын дагуу гишүүдийнхээ зүй бус авирын төлөө зохицуулах эрхтэй байж; ийм үйлсийг нөхөрлөл хийгээд сайн сайхан байдлын төлөө хэрэгжүүлдэг гэдэгт бид итгэдэг; гэвч шашны аливаа нийгэмлэг нь өмчийн эрх буюу амь насаар нь сорин турших, эсвээс тэднээс энэ дэлхийн өмчийг нь авах буюу амь нас хийгээд үе мөч аль алиныг нь хохирооход тэднийг хүргэх, эсвээс тэдэн дээр бие махбодийн аливаа шийтгэл үзүүлэх эрх мэдэлтэй гэдэгт бид итгэдэггүй. Тэд гагцхүү тэднийг өөрсдийн нийгэмлэгээс “хөөж, мөн өөрсдийн нөхөрлөлийг тэднээс татан авч болно.

11 Бүх буруу зүйл хийгээд гомдлуудыг барагдуулахын тулд бүх хүмүүс иргэний хуулинд хүсэх ёстой, энд хувь хүнд хохирол учруулсан буюу өмчийн эрх буюу нэр хүндэд хохирол учруулсан газарт ийм хуулиуд мөн үүнийг хамгаалах ёстой гэдэгт бид итгэдэг; харин бүх хүмүүс тэр даруйд хуулинд заалдаж болохгүй онцгой тохиолдолд өөрсдийгөө, найз нөхдөө, мөн өмч хөрөнгөө, бас засгийн газрыг хууль бус халдлагууд хийгээд дайралтуудаас хамгаалахад зөвтгөгдөж мөн хөнгөвчлөгддөг байх ёстой гэдэгт бид итгэдэг.

12 Сайн мэдээг дэлхийн бүх үндэстэнд “номлох, мөн зөв

шударгыг үйлдэгчдийг дэлхийн ялзралаас өөрсдийгөө хамгаалахыг нь сэрэмжлүүлэх нь шударга гэдэгт бид итгэдэг; сайн мэдээг номлох ч байна уу, мөн эздийнх нь таалал хийгээд хүслийн эсрэг тэдэнд баптисм хүртээх ч байна уу, энэ амьдрал дахь өөрсдийн нөхцөл байдалд сэтгэл ханамжтай бус байдалд тэднийг хүргэхэд хамгийн багаар хөндлөнгөөс оролцох буюу

тэдэнд нөлөөлөх ч байна уу ялгаагүй, үүгээр хүмүүсийн амьдралд хор хохирол учруулах замаар цалин авдаггүй үйлчлэгчид хөндлөнгөөс оролцох эрхтэй гэдэгт бид итгэдэггүй; ийм хөндлөнгийн оролцоо хууль бус бөгөөд шударга бус, мөн хүмүүнийг боолчлолд байлгахыг зөвшөөрдөг засгийн газар бүрийн амар амгалан байдалд аюултай гэдэгт бид итгэдэг.

ХЭСЭГ 135

1844 оны зургадугаар сарын 27-нд *Иллинойн Картейжид Бошиглогч Иосеф Смит болон түүний ах Патриарх Хайрум Смитийн амь насыг бүрэлгэсэн нь* (History of the Church, 6: 629–631). Уг үйл явдлын гэрч асан Арванхоёрын Зөвлөлийн Ахлагч Жон Тейлороор энэхүү баримт бичиг бичигджээ.

1–2, Иосеф, Хайрум хоёрын амь насыг Картейжийн шоронд бүрэлгэв; 3, Бошиглогчийн гаргуун байдал олонд мэдэгдэв; 4–7, Тэдний гэм зэмгүй цус уг ажлын үнэн хийгээд бурханлиг чанарын тухай гэрчилдэг.

ЭНЭ номны мөн Мормоны Номны тухай гэрчлэлийг лацдахын тулд, Бошиглогч “Иосеф Смит, мөн патриарх Хайрум Смит нарын амь насыг бүрэлгэснийг бид зарлан мэдэгдэж байна. Тэд 1844 оны зургадугаар сарын 27-нд “Картейжийн шоронд, нүүрээ хараар будсан, зэвсэглэсэн 150-200 танхайрагч

хүмүүсээр буудуулсан ажээ. “Хайрум эхлээд буудуулж; Би үхлээ хэмээн дуу алдаж, тайвнаар унав. Иосеф цонхоор үсрэхээр ухасхийж, буудуулан; Ай Их Эзэн Бурхан минь! хэмээн дуу алдав. Тэднийг хоёуланг амь алдсаных нь дараа, хэрцгийгээр буудаж, хоёул тус бүр дөрвөн суманд өртжээ.

2 Тэр үед уг өрөөнд байсан хүмүүс нь зөвхөн Арванхоёрын, “Жон Тейлор мөн Виллярд Ричардс хоёр бөлгөө; эхнийх нь дөрвөн зэрлэг суманд шархадсан хэдий ч, амьд мэнд үлджээ; сүүлчийнх нь Бурханы санаа тавилтаар

135 1a су Бага Иосеф Смит
б С ба Г 5:22; 6:30.

су Санаатайгаар алах, Санаатай аллага.
в су Картейжийн

шорон (АНУ).
г су Смит Хайрум.
2a су Жон Тейлор.

дамжин, хувцсандаа ганц ч нүхгүйгээр зугтаж амжсан ажээ.

3 Их Эзэний “Бошиглогч хийгээд ⁶Үзмэрч Иосеф Смит энэ дэлхийд хүмүүний авралын тулд, зөвхөн Есүс Христийг эс тооцвол үүн дээр амьдарч асан аль ч бусад хүнээс илүү ихийг хийсэн юм. Хорьхон жилийн богинохон хугацаанд тэрбээр Бурханы бэлэг хийгээд хүчээр өөрийн орчуулсан Мормоны Номыг урагш авчран, мөн үүнийг хоёр тивд хэвлүүлсэн арга хэрэгсэл нь болсон билээ; тэрбээр үүний агуулсан үүрдийн сайн мэдээний ⁶бүрэн байдлыг дэлхийн дөрвөн хязгаарт илгээв; хүмүүний үрсийн ашиг тусын төлөө Сургаал ба Гэрээний энэ номыг бүрдүүлсэн илчлэлтүүд хийгээд зарлигууд мөн мэргэн ухааныг агуулсан бусад олон баримт бичиг хийгээд заавруудыг урагш авчрав; Хожмын үеийн мянга мянган Гэгээнтнүүдийг цуглуулан агуу ‘хотыг үндэслэн байгуулж, мөн устгагдаж эс чадах алдар хийгээд нэрийг үлдээв. Тэрбээр Бурханы болон өөрийн хүмүүсийн мэлмийд агуу байдлаар амьдарч, мөн агуу байдлаар наснаас халив; мөн Их Эзэний эрт дээр үеийн томилогдогсдын адил өөрийн үүрэг зорилго хийгээд

өөрийн ажлуудыг ⁶цусаараа лацадсан бөлгөө; мөн түүний ах Хайрум ч бас ингэсэн билээ. Амьдралд тэд салсан нь үгүй, мөн үхэлд тэд тусдаа байсан нь үгүй!

4 Түүний амь насанд халдахаас хоёр буюу гурав хоногийн өмнө хуулийн шаардлагууд гэгч зохиомол зүйлд өөрийгөө тушаахаар Картейж уруу явахдаа Иосеф: “Хурга адил бибээр аллага уруу явж байна; гэвч би зуны өглөө лугаа тайван байна; Бурханд, мөн бүх хүмүүнд хүний мөсөөр гэм зэмгүй байхыг үргэлж хичээдэг билээ. Би гэм зэмгүйгээр үхэх болно, мөн миний тухай— тэрбээр САНААТАЙГААР АЛАГДСАН БӨЛГӨӨ ХЭМЭЭН ХЭЛЭГДЭХ БОЛНО гэж хэлжээ. Мөн тэр өглөө Хайрум явахаар бэлэн болсны дараа, аллага уруу хэмээн энэ нь хэлэгдсэн байх уу? Тийм ээ, учир нь энэ нь ийм байсан бөлгөө— тэрбээр Мормоны Номны Иферийн арванхоёрдугаар бүлгийн төгсгөл хавьд, дараах догол мөрийг уншиж, мөн дараах хуудсыг эргүүлэв:

5 Мөнхүү улиран тохиох дор тэд энэрлийг агуулж болохын тул, тэрээр харийнханд ач ивээлийг хайрлаасай хэмээн Их Эзэнд хандан би залбирсан буюу. Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн надад хэлэв: Хэрэв тэд энэрэл үгүй аваас, энэ

3а су Бошиглогч.
 б су Үзмэрч.
 в С ба Г 35:17; 42:12.
 су Сайн мэдээний

сэргээлт.
 г су Науву,
 Иллиной (АНУ).
 д Евр. 9:16–17;

С ба Г 136:39.
 4а Иса. 53:7.

нь танд хамаарах нь үгүй; чи итгэлтэй байсан; иймийн тул өмсгөл чинь “цэвэр болгогдох болно. Мөн чи өөрийн сул доройг харсан учир чи, миний Эцэгийн эзэмшилд, миний бэлтгэсэн тэр байранд суух хүртэл хүчирхэг болгогдох болно. Мөн эдүгээ би, харийнханд, тийм ээ, миний өмсгөлүүдэд та нарын цусны толбо үгүйг бүх хүмүүс мэдэх Христийн “шүүлтийн суудлын өмнө бид уулзах хүртэл мөн түүнчлэн өөрийн хайрт ах дүүстээ сайныг ерөөе. “Гэрчлэгчид эдүгээ нас нөгчсөн хэдий ч, мөн тэдний гэрчлэл хүчин төгөлдөр байна.

6 Хайрум Смит 1844 оны хоёрдугаар сард дөчин дөрвөн нас хүрсэн, мөн Иосеф Смит 1843 оны арванхоёрдугаар сард гучин найман настай байжээ; үүнээс хойш тэдний нэр шашны улмаас аллагад өртөгсдийн дунд ангилагдах болно; мөн Мормоны Ном, сүмийн Сургаал ба Гэрээ, ялзарсан дэлхийн авралын тулд тэдгээрийг урагш авчрахад арван есдүгээр зууны шилдэг цусны үнэ цэнийг үндэстэн бүхний уншигчдад сануулсаар байх болно; мөн хэрэв Бурханы алдар суугийн тулд түймрийн гал “ногоон модыг устгаж чадах аваас, ялзалын жимсний цэцэрлэгийг цэвэршүүлэхийн тулд, хуурай моддыг шатаах нь хичнээн амархан байх сан билээ; тэд

алдар суугийн тулд амьдарч байв; тэд алдар суугийн тулд нас нөгчсөн билээ; мөн алдар суу нь тэдний мөнхийн шагнал бөлгөө. Үеэс үед тэдний нэр нь ариусгагдсан тэдний тулд эрднийн чулуу лугаа адил үр удамд доош очих болно.

7 Тэд өмнө нь олонтаа нотлогдож байсанчлан, ямар ч гэмт хэрэгт холбогдолгүй байв; мөн урвагчид хийгээд ёс бус хүмүүсийн хуйвалдаанаар шоронд хаягдсан байлаа; мөн Картхейжийн шоронгийн шалан дээрх тэдний гэмгүй цус дэлхий дээрх аль ч шүүхээр няцаагдаж болохгүй Мормонизмд холбогдсон илт мэдэгдэхүйц лац болой, мөн Иллиной Муж улсын сүлд дээрх тэдний гэмгүй цус захирагчаар нь нотлогдсон, Муж улсын эвдэгдсэн итгэлийн хамт, бүх дэлхий ял тулгаж үл чадах үүрдийн сайн мэдээний үнэний тухай гэрчлэл юм; мөн эрх чөлөөний туг дээрх, мөн Нэгдсэн Улсын үндсэн хууль дээрх тэдний гэмгүй цус нь бүх үндэстний дундах шударга хүмүүсийн зүрх сэтгэлд хүрэх Есүс Христийн шашны хувьд элчин сайд нь юм; мөн тэдний гэмгүй цус нь “тахилын ширээний дор Иоханы харсан бүх аллагын гэмгүй цусны хамт, уг цусны өс хонзонг дэлхий дээр тэрбээр авах хүртэл Түмний Их Эзэнд хашгирсаар байх болно. Амен.

ХЭСЭГ 136

Айовагийн Каунсил Блаффсын ойролцоо Миссури мөрний баруун эрэг дээр Омаха үндэстний, Израилын буудал, Винтер Кворттерст Ерөнхийлөгч Бригам Янгаар дамжуулан өгөгдсөн Их Эзэний үг хийгээд таалал оршвой (Journal History of the Church, 1847 оны нэгдүгээр сарын 14).

1-16, Өрнө зүгт хийх аялалд Израилын буудал хэрхэн зохион байгуулагдах тухай тайлбарлагдав; 17-27, Гэгээнтнүүд сайн мэдээний олон тооны жишгүүдээр амьдрахаар зарлиг болгогдов; 28-33, Гэгээнтнүүд дуулж, бүжиглэн, залбирч, мөн мэргэн ухаанд суралцах ёстой; 34-42, Бошиглогчид хөнөөгддөг, иймээс тэд алдар хүндэтгэлтэй болох бөгөөд ёс бусчууд зүхэгддэг.

ӨРНӨД уруу хийх тэдний аяллууд дахь Израилын Буудлын талаарх Их Эзэний Үг хийгээд таалал нь:

2 “Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн бүх хүмүүс, мөн тэдэнтэй аялах тэд, бидний Бурхан Их Эзэний бүх зарлиг хийгээд дүрмүүдийг сахих гэрээ болон амлалт бүхий хамтлагууд болон зохион байгуулагдах.

3 Уг хамтлагууд нь “зуутын ахмадууд, тавьтын ахмадууд, мөн аравтын ахмадуудтай, өөрсдийн тэргүүнд ерөнхийлөгч болон хоёр зөвлөхтэйгөөр, Арванхоёр 6Төлөөлөгчийн удирдлага дор зохион байгуулагдах.

4 Мөн энэ нь — бид Их Эзэний бүх “ёслолд 6алхах болно гэсэн бидний 6гэрээ байх болно.

5 Хамтлаг бүр бүх зүтгэх мал, тэрэг, хүнс, материалын хангамжууд, хувцас хунар мөн аялалд шаардлагатай бусад зүйлүүдийг тэд чадлынхаа хэрээр өөрсдийгөө хангаг.

6 Хамтлагууд зохион байгуулагдахад үлдэх тэдний төлөө бэлтгэхийн тулд өөрсдийн хүч чадалтайгаар яваг.

7 Хамтлаг бүр өөрсдийн ахмадууд хийгээд ерөнхийлөгчдийн хамт хичнээн нь дараагийн хавар явж болохыг шийдэг; тэгээд хаврын тариалалтад бэлтгэх анхдагчууд болж явахын тулд зүтгэх мал, тарих үр, газар тариалангийн эд хогшлуудыг бэлтгэх, бие бялдрын хувьд чадалтай хийгээд дадлага туршлагатай чадварлаг хангалттай тооны хүмүүсийг сонгож аваг.

8 Бэлэвсэн эмэгтэйчүүд хийгээд эцэггүй хүүхдүүдийн гуйлтууд түүний өөрийнх нь хүмүүсийн эсрэг Их Эзэний

136 2a су Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм.

3a Ег. 18:21-26.
 6 су Төлөөлөгч.
 4a су Ёслолууд.
 б су Алхах,

Бурхантай хамт алхах.
 в су Гэрээ.

сонорт хүрэхгүйн тулд, хамтлаг бүр өөрсдийн өмч хөрөнгийн ноогдлын дагуу, “ядуус, ^ббэлэвсэн эмэгтэйчүүд, “эцэггүй хүүхдүүд, мөн цэрэгт явсан хүмүүсийн гэр бүлүүдийг тэнцүү тоогоор авч яваг.

9 Хамтлаг бүр энэ улирлын ард үлдэх тэдэнд зориулж байшингууд, тариалж тордох талбайнууд бэлтгэг; мөн энэ нь өөрийн хүмүүсийн талаарх Их Эзэний таалал бөлгөө.

10 Энэ хүмүүсийг Сионы “гадас болгон Их Эзэний байршуулах тэр газарт нүүлгэхийн тулд хүн болгон бүх нөлөө хийгээд өмч хөрөнгөө ашиглаг.

11 Мөн хэрэв та нар үүнийг цэвэр ариун зүрх сэтгэлээр, бүхий л итгэлтэй байдалд хийх аваас, та нар “адислагдах болно; та нар бог болон бод малаараа, мөн талбайнуудаараа, мөн орон гэрээрээ мөн өөрсдийн гэр бүлүүдээрээ адислагдах болно.

12 Миний үйлчлэгчид Эзра Т.Бенсон мөн Эрастус Снөү нар хамтлагийг зохион байгуулаг.

13 Мөн миний үйлчлэгчид Оорсон Пратт мөн Вилфорд Вудрафф нар хамтлагийг зохион байгуулаг.

14 Тэрчлэн миний үйлчлэгчид Амаса Лайман мөн Жорж

А.Смит нар хамтлагийг зохион байгуулаг.

15 Мөн ерөнхийлөгчид, мөн зуутуудын, мөн тавьтуудын бас аравтуудын ахмадуудыг томил.

16 Мөн томилогдсон байгаа, миний үйлчлэгчид явж мөн тэд амар амгалангийн нутаг уруу явахад бэлэн болсон байхын тулд, миний таалуудыг гэгээнтнүүдэд зааг.

17 Замаараа явж мөн та нарт миний хэлсэнчлэнгээр хийгтүн, мөн дайснуудаасаа бүү эмээ; учир нь миний ажлыг зогсоох хүч тэдэнд үгүй байх болно.

18 Сион миний өөрийн тогтоосон цагт “гэтэлгэгдэх болно.

19 Мөн хэрэв ямар ч хүн өөрийгөө төлөвшүүлэхийг эрэлхийлж, мөн миний “зөвлөгөөг үл эрэлхийлэх аваас, түүнд хүч байх нь үгүй, мөн түүний мунхаглал илэрхийлэгдэх болно.

20 Эрэлхийл та нар; мөн бие биендээ өгсөн бүх амлалтуудаа “биелүүлж бай; мөн ах дүүсийнх чинь болох зүйлд бүү ^бшуна.

21 Их Эзэний нэрийг дэмий хоосноор хэрэглэх хилэнцээс өөрсдийгөө “хол байлга, учир нь бибээр Их Эзэн, та нарын Бурхан, бүр та нарын эцгүүдийн ^бБурхан, Абрахам, мөн

8а су Ядуу.
б су Бэлэвсэн.
в Иаков 1:27;
3 Ниф. 24:5.
10а су Гадас.
11а Дэд хууль 28:1–14.

су Адислах,
Адислагдах,
Адислал.
18а С ба Г 100:13.
19а су Зөвлөгөө.
20а су Үнэнч, Үнэнч

шударга.
б су Шунах.
21а су Бүдүүлэг үг
хэллэг.
б Ег. 3:6; 1 Ниф. 19:10.

Исаак, мөн Иаковын Бурхан билээ.

22 “Би бол Израилын хүүхдүүдийг Египетийн нутгаас удирдан гаргасан тэрбээр билээ; мөн эцсийн өдрүүдэд өөрийн хүмүүс, Израилыг ⁶аврахын тулд миний гар урагш сунгагдах болой.

23 Бие биентэйгээ “сөргөлдөхөө эцэслэ; бие биенийхээ тухай ⁶хилэнцэтийг ярихаа эцэслэ.

24 “Архидан согтуурахаа эцэслэ; мөн үгс чинь бие биенээ ⁶сэнхрүүлэхэд чиглэг.

25 Хэрэв чи хөршөөсөө “зээлдсэн бол, чи зээлсэн тэр зүйлээ буцааж төлөх ёстой; мөн чи буцаан төлж чадахгүй бол тэрээр чамайг яллахгүйн тулд чи тэр даруй хөршдөө хэл.

26 Хэрэв чи хөршийнхөө “гээсэн зүйлийг олох аваас, үүнийг чи түүнд хүргэж өгөх хүртлээ хичээнгүйлэн хайх ёстой.

27 Чи мэргэн “даамал байж болохын тулд өөртөө байгаа юмыг хамгаалахад чи ⁶хичээнгүй байх ёстой; учир нь

энэ нь Их Эзэн Бурханы чинь үнэгүй бэлэг болой, мөн чи түүний даамал билээ.

28 Хэрэв чи аз жаргалтай байх аваас, Их Эзэнийг “дуугаар, хөгжмөөр, бүжгээр мөн магтаалын болон ⁶талархлын “залбирлаар магтагтун.

29 Хэрэв чи “уй гашуутай байх аваас сүнс чинь ⁶баяр хөөртэй байж болохын тулд Их Эзэн Бурханаа даруухан залбирлаар дуудагтун.

30 Дайснуудаасаа бүү эмээ, учир нь тэд миний гарт байгаа бөгөөд тэдний талаар би хүссэнээ хийх болно.

31 Тэдний тулд надад буй тэр “алдар сууг, бүр Сионы алдар сууг хүлээн авахад тэд бэлтгэгдэхийн тулд, миний хүмүүс бүх зүйлд зовлон зүдгүүр үзэн ⁶соригдох ёстой; мөн “зэмлэл үл даах тэрээр миний хаант улсын хувьд зохистой бус бөлгөө.

32 Мөн тэрээр харж болохын тулд, нүд нь нээгдэж, мөн тэрээр сонсож болохын тулд чих нь нээгдэхийн тулд өөрийгөө “даруусгаснаар, мөн Их Эзэн, Бурханаа дуудсанаар

22a Ег. 13:18;

Иер. 2:5–7;

1 Ниф. 5:15;

Алма 36:28.

су Иехова.

б Иер. 30:10;

Езек. 20:33–34;

С ба Г 38:33.

23a 3 Ниф. 11:29–30.

су Уруу таталт.

б С ба Г 20:54.

су Хилэнцэтийг

ярих.

24a су Мэргэн

Ухааны Үг.

б С ба Г 108:7.

25a Дуул. 37:21;

Мозая 4:28.

су Өр; Үнэнч,

Үнэнч шударга.

26a Лев. 6:4;

Дэд хууль 22:3.

27a су Даамал, Ажил

үүрэг.

б су Хичээл зүтгэл.

28a су Дуулах.

б Шаст. дэд 5:13;

С ба Г 59:15–16.

су Талархалтай,
Талархах, Талархал
өргөх.

в су Залбирал.

29a 2 Сам. 22:7.

б су Баяр баясгалан.

31a Ром. 8:18;

С ба Г 58:3–4.

су Алдар суу.

б С ба Г 101:4.

су Дайсан.

в су Зэмлэх, Зэмлэл.

32a су Даруу, Даруу

байдал.

үл хайхрагч тэрээр ⁶мэргэн ухаанд суралцаг.

33 Учир нь миний “Сүнс даруу төлөв хийгээд гэмшдэг тэднийг гэгээрүүлэхийн тулд, мөн бурханлиг бус тэднийг буруушаахын тулд дэлхийд урагш илгээгдсэн бөлгөө.

34 Ах дүүс тань, бүр та нарыг “хөөсөн үндэстэн та нарыг мөн та нарын гэрчлэлийг эсэргүүцсэн билээ.

35 Мөн эдүгээ тэдний гайтгүйтгэрийн өдөр, бүр уй гашуугийн өдрүүд, төрөхөөр шаналж буй эмэгтэйн адил ирэх буюу; мөн хэрэв тэд үтэр түргэн, нэн үтэр түргэн үл наманчлах аваас, тэдний уй гашуу агуу байх болно.

36 Учир нь тэд бошиглогчдыг, мөн өөрсөд уруу нь илгээгдсэн тэднийг хөнөөсөн билээ; мөн газраас тэдний эсрэг хашгирах гэмгүй цусыг тэд урсгасан билээ.

37 Тиймийн тул, эдгээр зүйлүүдэд бүү гайх, учир нь та нар хараахан “цэвэр ариун биш бөлгөө; та нар миний алдар сууг тэсэн гарах нь хараахан үгүй бөлгөө; харин, хэрэв та нар Адамын өдрүүдээс Абрахамыг хүртэл, Абрахамаас Мосег хүртэл, Мосегоос Есүс болон түүний төлөөлөгчид хүртэл, мөн Есүс

болон түүний төлөөлөгчдөөс бибээр өөрийн ажлыг урагш авчрахын тулд тохинуулагч үйлчлэгчид, ⁶тэнгэр элчүүдээрээ, мөн тэнгэрээс өөрийн дуу хоолойгоор дуудсан Иосеф Смитийг хүртэл та нарт миний “өгсөн бүх үгсийг минь сахихад итгэлтэй байх аваас, та нар үүнийг болгоох болно;

38 Тэрээр тэрхүү суурийг тавьсан юм, мөн итгэлтэй байв; мөн бибээр түүнийг өөртөө авсан билээ.

39 Түүний үхлийн улмаас олон хүн гайхсан билээ; гэвч тэрбээр алдар хүндийг хүлээж, мөн ёс бусчууд яллагдахын тулд өөрийн “гэрчлэлийг ⁶цусаар “лацдах ёстой нь шаардлагатай байсан ажгуу.

40 Та нарыг би “дайснуудаас чинь чөлөөлөөгүй, зөвхөн үүнд би нэрнийхээ гэрчийг үлдээсэн гэж үү?

41 Эдүгээ, тиймийн тул, анхаарагтун, Ай миний “сүмийн хүмүүс та нар; мөн ахлагчид та нар хамтдаа сонсоцгоо; та нар миний ⁶хаант улсыг хүлээн авсан билээ.

42 Та нар дээр шүүлтүүд ирэхгүйн тулд, мөн итгэл чинь та нарт алдагдахгүйн тулд, мөн дайснууд чинь та нарыг ялахгүйн тулд, миний

32b су Мэргэн ухаан.

33a су Ариун Сүнс.

34a су Хавчих,
Хавчлага.

37a су Цэвэр ариун,
Цэвэр ариун
байдал.

б Илч. 14:6;

С ба Г 110:11–16;
128:19–21;

ИС—Т 1:30–47.

в Хил. 8:18.

39a су Гэрчлэл.

б су Санаатайгаар
алах, Санаатай
аллага.

в Мозая 17:20;

С ба Г 135:3.

40a Ег. 23:22;

С ба Г 8:4; 105:15.

41a су Есүс Христийн
Сүм.

б Дан. 7:27.

бүх зарлигийг сахихад хичээнгүй бай. Эдүгээ үүнээс

илүү нь үгүй болой. Амен мөн Амен.

ХЭСЭГ 137

1836 оны нэгдүгээр сарын 21-нд Огайогийн Көртланд дахь ариун сүмд Бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн үзэгдэл оршвой (History of the Church, 2:380-381). Уг үйл явдал нь ариун сүмийн хишгийн ёслолууд илчлэгдэх үед тэдгээрийг гүйцэтгэсэн явдал байлаа.

1-6, Бошиглогч өөрийн ах Алвиныг селестиел хаант улсад харав; 7-9, Нас барагсдын авралын сургаал илчлэгдэв; 10, Бүх хүүхэд селестиел хаант улсад аврагддаг бөлгөө.

ТЭНГЭР бидэн дээр нээгдсэн байв, мөн Бурханы ^бселестиел хаант улсыг, мөн үүний алдар сууг бибээр болгоов, ^ббиенд үү, эсвээс гадна уу гэдгийг би хэлж үл чадна.

2 Тэр хаант улсыг өвлөгчдийн ордог “хаалганы хуйларсан галын ^бдөл лугаа адил үлэмж гоё сайхныг би харав;

3 Тэрчлэн дээр нь “Эцэг мөн ^бХүү залардаг Бурханы ^бгялалзсан сэнтийг болой.

4 Гаднах төрх нь “алтаар бүрсэн мэт харагдах тэр хаант улсын үзэсгэлэнт гудамжуудыг би харав.

5 “Адам Эцэг болон ^бАбрахамыг, мөн өөрийн “эцэг болон ‘эхийг, мөн дээр үед талийгаач болсон өөрийн ах ^аАлвиныг би харав;

6 Мөн Их Эзэн Израилыг цуглуулахын тулд гараа “хоёр дахь удаад сунгахаас өмнө тэрээр энэ амьдралыг орхисон хийгээд нүглүүдийн ангижралын тулд ^ббаптисм хүртээгүйг хараад, тэрээр хэрхэн энэ хаант улсад “өв хүлээн авсанд гайхашрав.

7 Ийн Их Эзэний “дуу хоолой надад ирж хэлэв: Энэ сайн

137 1a Үйлс 7:55-56;

1 Ниф. 1:8;
Хил. 5:45-49;
ИС—Т 1:43.

б су Селестиел алдар суу.

в 2 Кор. 12:2-4;
1 Ниф. 11:1;
Моце 1:11.

2a 2 Ниф. 9:41; 31:17.

б Ег. 24:17;
Иса. 33:14-15;
Хил. 5:23;
С ба Г 130:7.

3a су Бурхан, Бурхан тэргүүтэн —Эцэг Бурхан.

б су Бурхан, Бурхан тэргүүтэн —Хүү Бурхан.

в Иса. 6:1;
Езек. 1:26-28.

4a Илч. 21:21;
С ба Г 110:2.

5a су Адам.
б С ба Г 132:29.

в су Абрахам.
су Ахмад Иосеф Смит.

г су Смит, Люси Мак.

д ИС—Т 1:4.
6a Иса. 11:11;

1 Ниф. 22:10-12;

Иаков 6:2.
су Израил—
Израилын
цугларалт.

б Иохан 3:3-5;
2 Ниф. 9:23;
Ифер 4:18-19;
С ба Г 76:50-52;
84:74.

су Баптисм,
Баптисм хүртээх.
в су Нас барагсдын
аврал.

7a Хил. 5:30.
су Илчлэлт.

мэдээний тухай ^бмэдлэггүйгээр нас барсан тэд бүгд, үүнийг хүлээн авч болох тэд, хэрэв үлдэх нь тэдэнд зөвшөөрөгдсөн аваас, Бурханы ^сселестиел хаант улсыг ^өөлөгчид байх болно;

8 Тэрчлэн үүнээс хойш үүний тухай мэдлэггүйгээр нас барах тэд бүгд, үүнийг бүх зүрх сэтгэлээрээ хүлээн

авч “болох тэд, уг хаант улсыг өвлөгчид байх болно;

9 Учир нь Их Эзэн бибээр, бүх хүмүүнийг “ажлуудынх нь дагуу, зүрх сэтгэлийнх нь ^бхүслийн дагуу ^сшүүх болно.

10 Мөн тэрчлэн хариуцлагын “насанд хүрэхээсээ өмнө нас барсан бүх хүүхдүүд тэнгэрийн селестиел хаант улсад ^баврагддагийг бибээр болгоов.

ХЭСЭГ 138

1918 оны аравдугаар сарын 3-нд Ютагийн Солт Лейк Хотод Ерөнхийлөгч Иосеф Ф.Смитэд өгөгдсөн үзэгдэл оршвой. 1918 оны аравдугаар сарын 4-нд Сүмийн хагас жил тутмын 89-р Ерөнхий чуулганы нээлтийн үгэндээ Ерөнхийлөгч Смит өмнөх сарын турш бурханлиг хэд хэдэн заавар хүлээн авснаа зарлан тунхаглажээ. Цогцос нь булшинд байх үед аврагч нас барагсдын сүнснүүд дээр айлчилсан тухай Ерөнхийлөгч Смит эдгээрийн нэгийг өмнөх өдөр нь хүлээн авчээ. Энэ нь чуулганы хаалтын дараа тэр даруй бичигдсэн аж. 1918 оны аравдугаар сарын 31-нд энэ нь Тэргүүн Зөвлөлийн зөвлөхүүд, Арванхоёрын Зөвлөл, мөн Патриархад өргөн толилуулагдаж, мөн энэ нь тэднээр санал нэгтэйгээр хүлээн авагджээ.

1–10, Ерөнхийлөгч Иосеф Ф.Смит Петрийн бичээсүүд хийгээд сүнсний дэлхий дэх бидний Их Эзэний айлчлалын талаар тунгаан бодов; 11–24, Диваажинд цугласан нас нөгчсөн зөв шударгыг үйлдэгчдийг хийгээд тэдний дундах Христийн тохинууллыг Ерөнхийлөгч Смит харав; 25–37, Сайн мэдээний номлол сүнснүүдийн дунд хэрхэн зохион байгуулагддагийг тэрээр харжээ; 38–52, Адам

Ева хоёр, мөн сүнсний дэлхийд амилуулалтынхаа өмнө боолчлолд байгаа тэдний сүнсэн байдлыг цэгнэж буй ариун бошиглогчдоос олныг нь тэрээр харав; 53–60, Эдүгээ цагийн нас нөгчсөн зөв шударгыг үйлдэгчид өөрсдийн хөдөлмөрийг сүнсний дэлхийд үргэлжлүүлдэг.

МЯНГА есөн зуун арваннайман оны аравдугаар сарын гурванд, бибээр суд-

7б iso, 1 Петр 4:6;
2 Ниф. 9:25–26;
Мозая 15:24.
в су Селестиел алдар суу.
г С ба Г 76:50–70.
8а Алма 18:32;

С ба Г 6:16.
9а су Ажлууд.
б С ба Г 64:34.
су Зүрх сэтгэл.
в Илч. 20:12–13.
су Эцсийн шүүлт.
10а су Хариуцах,

Хариуцлага,
Хариуцлагатай.
б су Аврал—
Хүүхдүүдийн аврал.

руудын талаар “тунгаан бодсоор өрөөндөө сууж байлаа;

2 Мөн дэлхийн “гэтэлгэлийн төлөө Хүний Хүүгээр хийгдсэн тэрхүү” цагаатгагч агуу золиослолын талаар бясалган байсан буюу;

3 Мөн дэлхийд “Гэтэлгэгчийг ирэхэд Эцэг, Хүү хоёроор илэрхийлэгдсэн тэрхүү агуу хийгээд гайхамшигт” хайрын талаар буюу.

4 Түүний “цагаатгалаар дамжин мөн сайн мэдээний зарчмуудад” дуулгавартай байснаар хүмүүн төрөлхтөн аврагдаж болох тухай буюу.

5 Намайг ийн бодолд дарагдан байхад төлөөлөгч Петрийн бичээсүүд, Их Эзэнийг цовдлогдсоны дараа сайн мэдээ номлогдож байсан “Понт, Галат, Капподос болон азийн бусад хэсгүүд даяар алс холд тараагдсан эхэн үеийн” гэгээнтнүүд дээр оюун санаа минь бэлчиж байв.

6 Би Библийг нээж Петрийн эхний захидлын гурав ба дөрөвдүгээр бүлгүүдийг уншлаа, мөн уншиж байх зуур дараах хэсгүүд өмнө нь надад хэзээ ч байгаагүй тийм агуу ихээр сэтгэлийг минь догдуулав:

7 “Учир нь тэрээр биднийг

Бурханд аваачихын тулд Христ махан бие дотор егүүтгэгдэж, сүнс дотор амьдруулагдаж, зөвт нь зөвт бус хүмүүсийн оронд, нүглүүдийн төлөө нэгэнтээ зовсон ажээ:

8 “Тэрхүү Сүнсэнд тэрээр тэрчлэн явж, “шорон дахь сүнснүүдэд номлосон бөлгөө.

9 “Ноагийн өдрүүдэд хөвөгч авдар баригдаж байх үед Бурханы тэвчээр нь хүлээсээр байхад эдгээр сүнснүүд урьд нь дуулгаваргүй байв, тэрхүү хөвөгч авдарт цөөн буюу найман бодгаль байж уснаас эсэн мэнд гарчээ” (1 Петр 3:18-20).

10 “Учир нь тэд махан биеэрээ хүмүүсийн адил шүүгдэж, харин Бурханы хүслийн дагуу сүнс дотор амьдрахын тулд, энэхүү зорилгын үүднээс сайн мэдээ үхэгсдэд ч хүртэл тунхаглагдсан юм”. (1 Петр 4:6.)

11 “Бичигдсэн эдгээр зүйлүүдийн талаар намайг тунгаан бодож байхад ойлголтын минь” мэлмий нээгдэж, мөн Их Эзэний Сүнс над дээр “байж, түүнчлэн бибээр” нас барагсдыг, бяцхан хийгээд агуу аль алиныг нь үй олныг харав.

12 Мөн мөнх бус байдалд амьдарч байхдаа Есүсийн

138 1a су Тунгаан бодох.
2a су Гэтэлгэлийн төлөвлөгөө.
б Мат. 20:28.
су Цагаатгах, Цагаатгал.
3a су Гэтэлгэгч.
б Иохан 3:16.
су Хайр.

4a ИТ 1:3.
б Мат. 7:21.
су Дуулгавартай байх, Дуулгавартай, Дуулгавартай дагах.
5a 1 Петр 1:1.
б ө.х. Өмнөх үеийн гэгээнтнүүд.
8a Иса. 61:1; Лук 4:18;

С ба Г 76:73–74; 88:99.
11a су Судрууд— Судруудын үнэ цэнэ.
б Ефес 1:18;
С ба Г 76:10, 12, 19.
в Иса. 11:2.
г су Сүнс.

тухай гэрчлэлд “итгэлтэй байсан” шударга хүмүүсийн сүнсний тоо томшгүй хамтлаг тэнд нэг газарт цуглуулагдсан байлаа;

13 Мөн Бурханы Хүүгийн агуу их золиослолтой адил төстэй “золиослол хийсэн, мөн Гэтэлгэгчийнхээ нэрэнд гай зовлон” амссан тэд юм.

14 Эдгээр бүгд Бурхан “Эцэг болон түүний” Төрсөн Ганц Хүү Есүс Христийн “ач ивээлээр дамжсан, алдар суут” амилуулалтад “бат найдан, мөнх бус амьдралыг орхин оджээ.

15 Тэд “баясал хийгээд баяр хөөрөөр дүүрсэн байсныг, мөн тэдний чөлөөлөлтийн өдөр ойрхон байсны улмаас хамтдаа баясан цэнгэж байсныг бибээр болгоов.

16 Өөрсдийг нь үхлийн “хүлээснээс гэтэлгэснийг нь зарлан тунхаглахаар Бурханы Хүү” сүнсний дэлхийд ирэхийг хүлээн тэд хамтдаа цугласан байлаа.

17 Тэд бүрэн “баяслыг хүлээн авч болохын тулд тэдний нойрсолтын тоос үүнийхээ төгс хэлбэрт, “яс нь ясандаа, мөн шөрмөс хийгээд мах нь

тэдгээртээ, “сүнс хийгээд бие нь дахин хэзээ ч салахгүйгээр нэгдэхийн тулд” сэргээгдэх ёстой байв.

18 Энэхүү үй олон нь үхлийн гинжнээс өөрсдийнхөө чөлөөлөгдөх цагт баясан, хүлээж мөн ярилцан байтал, Бурханы Хүү заларч ирэн, итгэлтэй байсан боолчлогдогсод тэдэнд “эрх чөлөөг зарлан тунхаглав.

19 Мөн тэнд үүрдийн “сайн мэдээг, амилуулах хийгээд хүн төрөлхтний” уналтаас, мөн “наманчлалын нохцлоор хувь хүмүүсийн нүглүүдээс гэтэлгэх сургаалыг тэрбээр тэдэнд” номлов.

20 Харин “ёс бусчууд уруу тэрбээр очсонгүй, мөн бурхангүйчүүд мөн махан бодид байхдаа өөрсдийгөө “бузарласан үл наманчлагсдын дунд түүний дуу хоолой чангаар ярьсан нь үгүй;

21 Үүний адил эртний бошиглогчдын гэрчлэлийг хийгээд сануулгыг үгүйсгэсэн эсэргүүцэгчид ч түүний оршихуйг болгоож мөн түүний нүүрийг харсангүй;

22 Тэдний байсан тэнд, “харанхуй ноёлж, харин зөв

12a С ба Г 6:13; 51:19;
76:51–53.

б С ба Г 76:69–70.

13a су Золиослол.

б Мат. 5:10–12.

14a су Бурхан, Бурхан тэргүүтэн — Эцэг Бурхан.

б су Цорын Ганц.

в су Ач ивээл.

г су Амилуулалт.

д Ифер 12:4;

Моро. 7:3, 40–44.

су Найдвар.

15a Иса. 51:11;

Алма 40:12.

16a Морм. 9:13.

б Лук 23:43;

Алма 40:11–12.

су Диваажин.

17a су Баяр баясгалан.

б Езек. 37:1–14.

в С ба Г 93:33–34.

г 2 Ниф. 9:10–13.

18a Иса. 61:1.

су Нас барагсдын

аврал.

19a су Сайн мэдээ.

б су Адам, Ева

хоёрын Уналт.

в су Наманчлах,
Наманчлал.

г С ба Г 76:72–74.

20a Алма 40:13–14.

су Там; Ёс бус, Ёс бус явдал.

б 1 Ниф. 10:21.

22a су Сүнсний харанхуй.

шударгыг үйлдэгчдийн дунд
 6амар амгалан байв;

23 Мөн гэгээнтнүүд “гэтэл-гэлдээ баясан, мөн Бурханы Хүү өөрсдийнхөө Гэтэлгэгч мөн үхлээс хийгээд тамын 6гинжнээс Чөлөөлөгч хэмээн 6өвдөг сөгдөж мөн хүлээн зөвшөөрч байлаа.

24 Тэдний төрх байдал гялалзан, мөн Их Эзэний оршихуйн “хурц тод нь тэдэн дээр байлаа, мөн тэд түүний ариун нэрэнд магтуу 6дуулж байв.

25 Бибээр гайхашрав, учир нь иудейчүүдийн мөн Израилын угсааны тэдний дунд, тэдэнд үүрдийн сайн мэдээг заахыг хичээн, мөн тэднийг наманчлалд дуудан Аврагч өөрийн тохинуулалд гурван жил орчмыг өнгөрөөснийг би ойлгов.

26 Мөн бас, түүний хүчирхэг ажлууд, мөн ид шидүүд, бас агуу “хүч хийгээд эрх мэдэлд үнэний гунхаглал байсан хэдий ч, тэнд хэдхэн нь түүний дуу хоолойг сонсож, мөн түүний оршихуйд баясан, мөн авралыг түүний гараас хүлээн авсан ажгуу.

27 Харин нас барсан тэдний дундах түүний тохинуулал нь цовдлолт хийгээд түүний амилалтын хооронд өнгөрсөн “богинохон хугацаагаар хязгаарлагдсан болой;

28 Мөн заримдаа дуулгаваргүй байдаг шорон дахь сүнснүүдэд Бурханы тэсвэр тэвчээр Ноагийн өдрүүдэд нэгэнтээ хүлээж байхад Бурханы Хүү номлодог байсан тухай өгүүлсэн Петрийн үгст— мөн эдүгээ тэдгээр сүнснүүдэд зааж бас тийм богинохон хугацаагаар тэдний хувьд зайлшгүй шаардлагатай хөдөлмөрийг гүйцэтгэх нь түүнд хэрхэн боломжтой байсанд бибээр гайхашрав.

29 Мөн намайг гайхширан байх үед, миний мэлмий нээгдэж, мөн миний ойлголт “түргэсч, мөн ёс бусчуудын дунд, бас үнэнийг эсэргүүцдэг асан дуулгаваргүйчүүдэд, тэдэнд заахаар Их Эзэн өөрийн биеэр очоогүйг би ухаарав.

30 Гэвч болгоогтун, зөв шударгыг үйлдэгчдийн дундаас тэрбээр өөрийн хүчийг зохион байгуулж, мөн элч нарыг томилон “хүч чадал хийгээд эрх мэдлээр хувцаслаж, мөн урагш одон 6харанхуйд байсан тэдэнд, бүр хүмүүний 6бүх сүнснүүдэд сайн мэдээний гэрлийг хүргэн, мөн итгэмжлэлийг тэдэнд олгодог байв; мөн тийн сайн мэдээ нь нас барагсдад номлогддог байлаа.

31 Мөн сонгогдсон элч нар

22б су Амар амгалан.

23а су Гэтэлгэлийн төлөвлөгөө.

б 2 Ниф. 1:13;

Алма 12:11.

в Ром. 14:11;

Мозая 27:31.

24а Дуул. 104:1–2;

Иса. 60:19;

Илч. 22:5;

ИС—Т 1:17.

су Гэрэл, Христийн гэрэл.

б су Дуулах.

26а 1 Ниф. 11:28.

27а Марк 8:31.

29а С ба Г 76:12.

30а Лук 24:49.

б су Сүнсний харанхуй.

в С ба Г 1:2.

Их Эзэний хувьд “хүлээн зөвшөөрч болохуйц өдрийг зарлан тунхаглах, мөн хүлээсэнд байсан боолчлогдогсод, бүр нүглүүдээсээ наманчилж мөн сайн мэдээг хүлээн авч болох тэд бүгдэд ^бэрх чөлөөг тунхаглахаар урагш оддог байв.

32 Үнэний тухай “мэдлэггүйгээр, эсвээс бошиглогчдыг эсэргүүцсэний улмаас зөрчилд, нүглүүддээ ^бнас нөгчсөн тэдэнд сайн мэдээ тийн номлогддог байв.

33 Бурханд итгэх “итгэл, нүглээс наманчлах, нүглүүдийн ^бангижралын тул ^атөлөөлөн хийх баптисм, гар тавилтаар Ариун Сүнсний ^вбэлэг хүртээхийг тэдэнд заадаг байлаа,

34 Мөн тэд махан бие дэх хүмүүсийн дагуу “шүүгдэж, харин Бурханы дагуу сүнсэнд амьдрахад өөрсдийгөө тохирохоор болгохын тулд тэдний хувьд мэдэх шаардлагатай сайн мэдээний бусад бүх зарчмыг болой.

35 Мөн тийн Бурханы Хүүгийн “загалмай дээрх ^бзолиослолоор дамжин гэтэлгэл хийгдсэн гэдгийг ийн нас барагсад, бяцхан хийгээд агуу, шударга бусчууд хий-

гээд түүнчлэн итгэлтнүүдийн дунд аль алинд нь мэдүүлэгдсэн буюу.

36 Бидний Гэтэлгэгч, махан биед өөрийнх нь тухай гэрчилдэг асан “бошиглогчдын тухай итгэлтэй сүнснүүдэд зааварлан мөн бэлтгэж, сүнсний дэлхийд түр амьдарч байхдаа цаг заваа зориулдаг байсан нь ийнхүү мэдүүлэгдсэн бөлгөө;

37 Тэд гэтэлгэлийн бүх захиасыг бүх нас барагсад, “эсэргүүцэл хийгээд зөрчлийнх нь улмаас тэрбээр биеэрээ очиж үл чадах тэдэнд хүргэж болохын тулд, түүний үйлчлэгчдийн тохинууллаар дамжуулан тэд тэрчлэн түүний үгсийг сонсож болохын тулд буюу.

38 Зөв шударгыг үйлдэгчдийн энэхүү асар том цугларалтад хуран цугласан агуу хийгээд хүчирхэг хүмүүсийн дунд Эртний Өдрүүд мөн бүхний эцэг “Адам Эцэг байлаа,

39 Мөн бүхний алдар суут “Ева Эх, үе үеийн туршид амьдарч, үнэн бөгөөд амьд Бурханыг шүтэн биширч асан, итгэлт охидынхоо олонтой хамт байв.

31a Иса. 61:2;
Лук 4:17–19.
^б су Эрх чөлөө.
32a С ба Г 128:5.
су Мэдлэг.
^б Иохан 8:21–24.
33a ИТ 1:4.
су Итгэл.
^б су Нүглүүдийн ангижрал.
^в су Баптисм,

Баптисм хүртээх—
Нас барагсдын төлөөх Баптисм;
Ёслолууд—Бусдын өмнөөс үйлдэх ёслол.
^г су Ариун Сүнсний бэлэг.
34a су Эцсийн шүүлт.
35a су Загалмай;
Цовдлуулалт.

^б Алма 34:9–16.
су Цагаатгах,
Цагаатгал;
Золиослол.
36a С ба Г 138:57.
37a С ба Г 138:20.
су Эсэргүүцэл.
38a су Адам.
39a Моце 4:26.
су Ева.

40 Анхны “алагдагч ^бАбел, мөн түүний дүү, эцэг Адамынхаа ^бдүр төрхийг илэрхийлдэг асан, хүчирхэг хүмүүсийн нэг ^сСет тэнд байв.

41 Үерийн тухай сэрэмжлүүлэгдсэн “Ноа; агуу ^бдээд санваартан ^бШем; итгэлтнүүдийн эцэг ^вАбрахам; ^бИсаак, ^бИаков, мөн Израилын агуу ^бхууль тогтоогч Моце болой;

42 Мөн харууссан зүрхтэнгүүдэд тайтгарлыг өгч, “боолчлогдогсдод эрх чөлөөг мөн хүлэгдсэн тэдэнд ^бшоронг нээхийг тунхаглахаар Гэтэлгэгч томилогдсон гэдгийг бошиглолоор зарлан тунхагласан ^бИсаиа тэрчлэн тэнд байв.

43 Түүнээс гадна, үзэгдэлд нас барагсдын “амилуулалтад амьд бодгалиуд болж дахин урагш гарч ирэх, махаар бүрэгдэх ^бхувхайрсан яснуудын агуу хөндий, түүнд харагдсан ^бЕзекиел болой;

44 Дахин хэзээ ч үл устгагдан, мөн бусад хүмүүст үл өгөгдөх Бурханы “хаант улс хожмын өдрүүдэд үндэслэн байгуулагдахыг угтан харж,

мөн угтан хэлсэн ^бДаниел болой;

45 “Хувиралтын Уулан дээр Мосетой хамт байсан ^бЕлиас болой;

46 Мөн түүний тухай Моронай бас Бошиглогч Иосеф Смитэд ярин, тэрбээр Их Эзэний агуу хийгээд аймшигт “өдөр эхлэхийн өмнө ирэх ёстой хэмээн тунхагласан ^бЕлиагийн ирэлтийн тухай гэрчилсэн бошиглогч ^бМалахи тэрчлэн тэнд байв.

47 Бошиглогч Елиа эцгүүдэд нь хийгдсэн амлалтуудыг хүүхдүүдийнх нь “зүрх сэтгэлд суулгах ёстой байв,

48 Бүхэл дэлхий зүхлээр цохигдож мөн түүний ирэлтээр бүрмөсөн устгагдахгүйн тулд, нас барагсдын гэтэлгэлийн тулд, мөн хүүхдүүдийг эцэг эхчүүдтэй нь “лацдан холбохын тулд, цаг хугацааны бүрэн байдлын ^бЭрин үед Их Эзэний “ариун сүмүүдэд хийгдэх агуу ‘ажлыг угтан харуулсан буюу.

49 Тэд бүгд мөн өөр олон нь, бүр нифайчуудын дунд амьдарч, мөн Бурханы Хүү-

40a су Санаатай алах, Санаатай аллага.

б су Абел.

в Эхл. 5:3; Моце 6:10.

г су Сет.

41a су Ноа, Библийн патриарх.

б су Дээд санваартан.

в су Шем.

г Эхл. 17:1–8.

су Абрахам.

д Эхл. 21:1–5.

су Исаак.

е Эхл. 35:9–15.

су Иаков,

Исаакийн хүү.

ё су Моце.

42a Иса. 61:1–2.

б су Там.

в су Исаиа.

43a су Амилуулалт.

б Езек. 37:1–14.

в су Езекиел.

44a Дан. 2:44–45.

су Бурханы хаант

улс буюу Тэнгэрийн хаант улс.

б су Даниел.

45a су Хувиралт.

б су Елиа.

46a су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

б С ба Г 110:13–15.

су Елиа.

в Малах. 4:5–6;

ИС—Т 1:36–39.

су Малахи.

47a С ба Г 128:17.

48a су Гэр бүл—

Мөнхийн гэр бүл;

Лацдах, Лацдалт.

б су Эрин үе.

в су Ариун Сүм, Их

Эзэний Өргөө.

г су Нас барагсдын

аврал.

гийн ирэлтийн тухай гэрчилж асан “бошиглогчид тэрхүү асар том цугларалтад байлцаж мөн чөлөөлөлтөө хүлээж байв,

50 Учир нь нас барагсад өөрсдийнх нь “сүнс биенээс нь салаад их удсаныг ^ббоолчлол хэмээн үздэг ажгуу.

51 Тэдэнд Их Эзэн зааж, мөн нас барагсдаас тэрээр амилагдсаны дараа, “үхэшгүй байдал хийгээд ^бмөнх амьдралаар титэмлэгдэх түүний Эцэгийн хаант улсад орохын тулд урагш гарч ирэх “хүчийг тэдэнд өгчээ,

52 Мөн Их Эзэнээр амлагдсанчлан тэр цагаас хойш хөдөлмөрөө үргэлжлүүлж, мөн өөрийг нь хайрладаг тэдний төлөө хадгалагдаж байсан бүх “адислалыг хүртэгчид байх тэрхүү хүчийг буюу.

53 Бошиглогч Иосеф Смит, мөн миний эцэг, Хайрум Смит, Бригам Янг, Жон Тейлор, Вилфорд Вудрафф, мөн хожмын үеийн агуу их ажлын “суурийг тавихад оролцохоор цаг хугацааны бүрэн байдалд урагш гарч ирэхээр ^бхадглагдсан, бусад сонгомол сүнснүүд,

54 Үүний дотор ариун сүмүүдийг барих хийгээд “нас

барагсдын гэтэлгэлийн төлөө тэнд хийгдэх ёслолуудын гүйцэтгэл, тэд бас сүнсний дэлхийд байв.

55 Бурханы Сүмд удирдагчид байхаар эхлэлд “сонгогдсон, ^бёс суртахуунаар өв тэгш хийгээд агуу хүмүүсийн дунд тэд тэрчлэн байсныг бибээр ажигласан бөлгөө.

56 Бүр тэд төрөхөөсөө өмнө, бусад олны хамт, сүнсний дэлхийд анхныхаа хичээлүүдийг хүлээн авч, мөн Их Эзэний тогтоосон “цагт хүмүүний бодгалиудын авралын төлөө түүний ^бталбайд хөдөлмөрлөхийн тулд урагш гарч ирэхээр “бэлтгэгдсэн байжээ.

57 Энэ эрин үеийн итгэлт “ахлагчид, тэд мөнх бус амьдралаас хагацахдаа, Бурханы Төрсөн Ганц Хүүгийн золиослолоор дамжуулан ^бхаранхуйд байгаа тэд болон нас барагсдын сүнснүүдийн агуу дэлхийд нүглийн боолчлол дор буй тэдний дунд наманчлалын болон гэтэлгэлийн сайн мэдээг номлох хөдөлмөрөө үргэлжлүүлдэг болой.

58 Наманчилдаг нас барагсад, Бурханы өргөөний “ёслолуудад дуулгавартай

49a Хил. 8:19–22.

50a су Сүнс.

б С ба Г 45:17.

51a су Мөнх бус, Мөнх бус байдал.

б С ба Г 29:43.

су Мөнх амьдрал.

в 1 Кор. 6:14;

Алма 40:19–21.

52a Иса. 64:4;

1 Кор. 2:9;

С ба Г 14:7.

53a С ба Г 64:33.

б су Урьдчилсан томилолт.

54a су Ёслолууд— Бусдын өмнөөс үйлдэх ёслол.

55a су Урьдчилсан томилолт.

б Абр. 3:22–24.

56a Үйлс 17:24–27.

б Иаков 6:2–3.

су Их Эзэний талбай.

в Иов 38:4–7;

Алма 13:3–7.

57a су Ахлагч.

б су Там.

58a су Ёслолууд.

байснаар дамжуулан ⁶гэтэлгэгдэх болно,

59 Мөн тэд зөрчлийнхөө цээрлэлийг төлсний, мөн “угаагдан цэвэршсэний” дараа, ⁶ажлуудынхаа дагуу шагналаа хүлээн авах болно, учир нь тэд авралыг өвлөгчид бөлгөө.

60 Нас барагсдын гэтэлгэлийн тухай надад илчлэгдсэн үзэгдэл ийн байсан бөлгөө, мөн бибээр гэрчилнэ, мөн бидний Их Эзэн бас Аврагч, Есүс Христийн адислалаар дамжуулан энэхүү гэрчлэл “үнэн гэдгийг би мэднэ, бүр тийм буюу. Амен.

АЛБАН ТУНХАГ — 1

Холбогдох хүмүүсийн сонорт:

Улс төрийн зорилгоор Солт Лейк хотоос илгээж буй, өргөнөөр нийтлэгдсэн хэвлэлийн мэдэгдлүүд, Ютагийн Комиссоос Дотоод Хэргийн Төрийн Нарийн Бичгийн даргад явуулсан саяхны илтгэлдээ олон эхнэр авах ёсыг өдгөө хүртэл онцгой ариун ёслол болгон гүйцэтгэж байгаа бөгөөд Ютад өнгөрсөн зургадугаар сараас хойш буюу өнгөрсөн жилийн хугацаанд дөч буюу түүнээс олон ийм гэрлэлт бүртгэгдсэн хийгээд мөн түүнчлэн Сүмийн удирдагчид олон эхнэртэй байх ёсыг үргэлжлүүлэхийг олны өмнө өөгшүүлэн дэмжиж, мөн шавдуулдаг хэмээн мэдээлжээ —

Тиймийн тул, үүгээр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгч миний бие, эдгээр мэдэгдлүүд худал гэдгийг хамгийн эрс хатуугаар мэдэгдэж байна. Бид олон эхнэртэй байх ёс буюу эхнэр авах ёсыг заадаггүй, мөн ийм дадал зуршилтай байхыг хэнд ч зөвшөөрдөггүй бөгөөд манай Ариун сүмүүдэд юм уу эсвэл Нутаг дэвсгэрийн аль ч газарт дөч юм уу өөр ямар нэг тооны олон эхнэр авсан гэрлэлт энэ хугацаанд онцгой ариун ёслолын байдалтайгаар болсон гэдгийг миний бие үгүйсгэж байна.

Ийм гэрлэлт 1889 оны Хавар Солт Лейк хотод, Хишигийн өргөөнд гүйцэтгэгдсэн мэтээр талууд мэдэгдсэн хэмээх нэгэн баримт мэдээлэгджээ, гэвч ёслолыг хэн гүйцэтгэснийг мэдэх боломж надад үгүй байна; энэ асуудлаарх аливаа зүйл надад мэдэгдэлгүйгээр хийгджээ. Мэдээлэгдсэн тохиолдол нь Хишигийн өргөө байсны улмаас, миний заавраар, хойшлууулалгүйгээр хаагдсан болно.

Олон эхнэр авах ёсыг хориглосон хуулиуд Конгрессоор боловсруулагдан, эдгээр хуулиудыг үндсэн хуульд нийцүүлс-

58б су Гэтэлгэх,
Гэтэлгэгдэх,
Гэтэлгэл.

59а Алма 5:17–22.
су Уучлах.
б су Ажлууд.

60а су Үнэн.

нээр эцсийн шийдвэр гаргах нь шүүхээр тунхаглагдсан учраас, миний зорилго бол эдгээр хуулиудыг дагаж мөн өөрийн тэргүүлдэг Сүмийн гишүүдийн талаарх нөлөөгөө ашиглан, тэднийг мөн адил дагахыг миний бие мэдэгдэх явдал мөн.

Дээр дурдсан хугацаанд Сүм дэх буюу өөрийн хэлхээ холбоотой байдаг хүмүүст миний заасан зүйлүүдэд, олон эхнэртэй байх ёсыг зөвтгөн тайлбарлаж ухуулсан буюу хөхиүлэн дэмжсэн гэхээр зүйл юу ч байхгүй; мөн тус Сүмийн аль ч ахлагч иймэрхүү аливаа заалтыг дамжуулсан гэхээр үг хэллэг хэрэглэсэн тохиолдолд тэрээр тэр даруй зэмлэгддэг билээ. Тийнхүү Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд өгдөг миний зөвлөгөө бол улс орны хуулиар хориглогдсон аливаа гэрлэлт хийхийг цээрлэх явдал мөн гэдгийг миний бие эдүгээ олон нийтийн өмнө зарлан мэдэгдэж байна.

ВИЛФОРД ВУДРАФФ

Есүс Христийн Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгч

Ерөнхийлөгч Лорензо Снөү дараах зүйлийг санал болгов:

“Вилфорд Вудраффyг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгч, мөн өнөө үед лацдан холбох ёслолуудын түлхүүрүүдийг атгадаг, дэлхий дээрх цорын ганц хүн хэмээн хүлээн зөвшөөрдгийн хувьд, 1890 оны есдүгээр сарын 24-ний өдрөөр хаяглагдсан, мөн бидэнд уншиж сонсгосон Тунхаг Бичгийг албан тушаалынхаа хүч нөлөөгөөр гаргахад тэрбээр бүрэн эрх мэдэлтэй хэмээн бид үзэж, мөн Ерөнхий чуулганд цугласан Сүмийн хувиар, бид олон эхнэр авах ёсны талаарх түүний тунхгийг эрх мэдэлтэй хийгээд хүчин төгөлдөр үүрэг хүлээлгэсэн хэмээн хүлээн авахыг миний бие санал болгож байна”.

Энэхүү байр суурийг дэмжих санал хураалт бүрэн нэгдмэл байв.

Юта, Солт Лейк хот, 1890 оны аравдугаар сарын 6

ТУНХАГ БИЧГИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙЛӨГЧ
ВИЛФОРД ВУДРАФФЫН ГУРВАН УДААГИЙН
ХЭЛСЭН ҮГНЭЭС АВСАН ХЭСЭГ

Та нарыг замыг нь алдагдуулахыг надад буюу энэ Сүмийн Ерөнхийлөгчөөс өөр хэнд ч, хэзээ ч Их Эзэн үл зөвшөөрөх болно. Энэ нь хөтөлбөрт байхгүй. Энэ нь Бурханы оюунд байхгүй. Хэрэв би үүнийг хийхээр хичээх аваас,

Их Эзэн намайг албан тушаалаас минь зайлуулах буйза, мөн хүмүүний үрсийг Бурханы илчлэлтүүд хийгээд өөрсдийнх нь үүргээс гажуудуулахаар оролдсон бусад хэнийг ч Тэрбээр мөн үүнчлэн зайлуулах болно (Сүмийн хагас жил тутмын жараннэг дэх ерөнхий чуулган, 1890 оны аравдугаар сарын 6, Даваа гараг, Солт Лейк Хот, Юта *Deseret Evening News-д 1890 оны аравдугаар сарын 11-нд нийтлэгджээ, хуудас 2.*)

Хэн амьдарч байгаа, эсвээс хэн нас барсан, эсвээс хэн энэ Сүмийг удирдахаар дуудагдсан нь хамаагүй, тэд Бүхнийг Чадагч Бурханы нөлөөллөөр үүнийг удирддаг билээ. Хэрэв тэд үүнийг ийм замаар хийж үл чадах аваас тэд үүнийг ерөөсөө хийж чадахгүй . . .

Мөн сүүлийн үед миний хувьд нэн чухал ач холбогдолтой илчлэлтүүдийг би хүлээн авсан билээ, мөн Их Эзэн надад хэлсэн зүйлийг би та нарт ярих болно. Тунхаг бичиг хэмээн томъёологдсон тэрхүү зүйлд та нарын оюун санааг хандуулахыг надад зөвшөөрнө үү . . .

Хожмын Үеийн Гэгээнтнүүдээс нэг асуулт асуухыг Их Эзэн надад хэлсэн билээ, мөн хэрэв тэдэнд миний хэлснийг тэд сонсож мөн тэдэнд тавьсан асуултад Сүнсээр хийгээд Бурханы хүчээр хариулах аваас, тэд бүгдээрээ нэгэн адилаар хариулах болно, мөн тэд бүгдээрээ энэ асуудлын талаар адилхан итгэх болно хэмээн Тэрбээр тэрчлэн надад ярьсан бөлгөө.

Тэр асуулт нь энэ байна: Улс орны хуулиудын эсрэг, мөн жаран сая хүмүүсийн эсрэг олон эхнэр авах ёсны дадал зуршлыг үргэлжлүүлэхийг хичээж, мөн бүх Ариун сүмүүдийг хураалган бас алдахын үнэ цэнээр, бас тэдгээр дэх бүх ёслолуудыг, амьд байгаа хүмүүсийн болон нас барагсдын төлөөх аль алиныг нь зогсоон, бас Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрыг мөн Сүм дэх гэр бүлийн тэргүүнүүдийг шоронд суулгаж, мөн хүмүүсийн (тэд бүгд өөрсдөө уг зуршлыг орхих болно) хувийн өмчийг хураалгах уу; эсвэл, уг зуршлыг орхиж, мөн хуулинд захирагдах энэхүү зарчимд дуулгавартай байхаар дамжуулан өөртөө байгаа юмыг гүйцэтгэж мөн хүлцэн тэвчсэний дараа, мөн үүнийг хийснээрээ тэд хүмүүст зааварлаж мөн Сүнсний үүргүүдийг биелүүлж, мөн түүнчлэн Ариун Сүмүүдийг Гэгээнтнүүдийн гарт үлдээн, тэрчлэн тэд Сайн мэдээний ёслолуудыг, амьд байгаа хүмүүс хийгээд нас барагсдын төлөөх аль алиныг нь гүйцэтгэж болохын тулд Бошиглогчид, Төлөөлөгчид хийгээд гэр бүл дэх эцгүүдийг хэвээр үлдээх үү гэдгийн аль нь Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хувьд хамгийн ухаалаг зам бэ?

Хэрэв бид энэ зуршлыг эс зогсоовол, чухам юу тохиохыг Их Эзэн үзэгдлээр хийгээд илчлэлтээр надад үзүүлсэн бөлгөө. Хэрэв бид үүнийг эс зогсоох аваас, Логан дахь энэ ариун сүм дэх аль ч хүмүүн нь та нарын хувьд ямар ч ашиг тусгүй байх болно; учир нь Сионы нутаг даяар бүх ёслолууд зогсоно. Израил даяар эмх замбараагүй явдал газар авч, мөн олон эрчүүд хоригдол болохвий. Энэхүү таагүй хэрэг явдал Сүм даяар тархаж, мөн уг зуршлыг зогсоохоор бид албадуулагдах болно. Эдүгээ, энэ нь ийм байдлаар албадлагаар зогсох ёстой юу эсвэл, Их Эзэн бидэнд үзүүлсэн тэр замаар өөрсдийн Бошиглогчид хийгээд Төлөөлөгчид түүнчлэн эцгүүдээ чөлөөт хүмүүс хэвээр, мөн нас барагсад гэтэлгэгдэж, ариун сүмүүдийг хүмүүсийн гарт хэвээр үлдээх үү гэдэг нь асуудал болоод байна. Сүнсний дэлхийд энэ хүмүүсээр асар олон тоотой нь шоронгийн байрнаас аль хэдийн чөлөөлөгдөөд байгаа бөгөөд, уг ажил цаашид үргэлжлэх үү, эсвэл зогсох уу? Энэ нь Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн өмнө тавих миний асуулт болой. Та нар өөрсдөө шүүн тунгаах ёстой. Үүнд та нар өөрсдөө хариулахыг би хүсч байна. Би үүнд хариулахгүй; харин энэ бол бидэнд буй тэр замыг бид эс сонговоос, хүмүүсийн хувьд бидэнд тулгарч болох тэрхүү нөхцөл байдал яах аргагүй мөн гэдгийг би та нарт хэлж байна.

. . . Хэрэв ямар нэг юм хийхгүй бол юу тохиохыг би яг харсан. Урт удаан хугацааны турш энэ сүнс над дээр байгаа билээ. Харин бибээр үүнийг хэлэхийг хүснэ: Бүх ариун сүм бидний гараас гарахад би хүргэх болно; би өөрөө шоронд орохоос аргагүйд хүрнэ, мөн өөр бусад хүн болгоныг тийшээ очиход хүргэнэ, миний хийснийг хий хэмээн тэнгэрийн Бурхан надад зарлиглаагүй; мөн цаг нь ирэхэд үүнийг хийхээр би зарлиг болгогдсон бөлгөө, энэ бүгд надад тодорхой байлаа. Би Их Эзэний өмнө очиж, мөн Их Эзэн бич хэмээн надад хэлснийг бибээр бичсэн билээ . . .

Та нарыг тунгаан бодож мөн эргэцүүлэг хэмээн үүнийг миний бие та нарт үлдээе, Их Эзэн бидэнтэй хамт ажиллаж байна. (Cache Stake Conference, Logan, Utah, Sunday, November 1, 1891. Reported in *Deseret Weekly*, November 14, 1891.)

Надад юу үзүүлэгдсэн хийгээд Бурханы Хүү энэ зүйлд юу гүйцэтгэснийг одоо би та нарт ярья . . . мөн уг Тунхаг бичиг өгөгдөөгүй бол Бүхнийг Чадагч Бурхан амьдардгийн адил эдгээр бүх зүйл тохиох байлаа. Тиймийн тул, Бурханы Хүү өөрийн оюун дахь зорилгуудын учир энэ зүйлийг Сүмд, мөн дэлхийд толилуулах хүсэлтэй байна. Сионыг үндэслэн байгуулахыг Их Эзэн тогтоосон билээ. Тэрээр энэ ариун сүмийг дуусгахыг тогтоосон билээ. Амьд байгаа хүмүүс хийгээд нас барагсдын аврал нь уулсын эдгээр хөндийнүүдэд өгөгдөх ёстой хэмээн Тэрбээр тогтоосон билээ. Мөн Чөтгөр үүнийг саатуулах ёсгүйг Бүхнийг Чадагч Бурхан тогтоосон билээ. Хэрэв та нар үүнийг ойлгож чадах аваас, тэр нь үүний түлхүүр мөн. (1893 оны дөрөвдүгээр сард Солт Лейкийн Ариун Сүмийг онцгойлон адислах зургадугаар хуралдаан дээрх ярианаас. Онцгойлон адислах Үйлчлэлийн баримт бичиг, Church Historical Department-ийн Газар, Юта, Солт Лейк Хотын Архив).

АЛБАН ТУНХАГ — 2

Холбогдох хүмүүсийн сонорт:

1978 оны есдүгээр сарын 30-нд, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хагас жил тутмын 148-р Ерөнхий чуулган дээр дараах зүйл нь Сүмийн Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Н.Элдон Таннераар толилуулагдав:

Санваар хийгээд Сүмийн зохистой бүх эрэгтэй гишүүдэд ирэх ариун сүмийн адислалуудын талаар нэгэн илчлэлт Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллаар хүлээн авагдсаныг энэ оны зургадугаар сарын эхээр Тэргүүн Зөвлөл зарласан билээ. Ариун сүмийн нандин өрөөнүүд дэх удаан бясалгал хийгээд залбирлын дараа түүнд ирсэн энэхүү илчлэлтийг тэрээр хүлээн авсны дараа уг чуулганд намайг мэдээлнэ үү хэмээн Ерөнхийлөгч Кимбалл надаас хүссэн юм, тэрбээр үүнийг хүлээн авч мөн баталсан зөвлөхүүддээ үүнийг толилуулсан билээ. Тийнхүү үүнийг санал нэгтгэйгээр баталсан Арванхоёр төлөөлөгчийн чуулганд толилуулав, мөн дараа нь залгаад мөн үүнийг санал нэгтгэйгээр баталсан Сүмийн бүх Ерөнхийлөн удирдах эрх мэдэлтнүүдэд толилуулсан бөлгөө.

Эдүгээ намайг энэ захидлыг уншина уу хэмээн Ерөнхийлөгч Кимбалл хүссэн юм:

1978 оны зургадугаар сарын 8

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн дэлхий даяарх ерөнхий болон орон нутгийн санваартны бүх албан тушаалтнуудад:

Эрхэм хүндэт Ах нар аа:

Дэлхий даяар Их Эзэний ажил өргөжин тэлж байгааг бид гэрчлэхийн хамт, олон үндэстний хүмүүс сэргээгдсэн сайн мэдээний захиаст нааштайгаар хандан, Сүмд нэгдэх нь тооны хувьд байнга өсөн нэмэгдэж байгаад бид баяртай байдаг билээ. Энэ нь эргээд, сайн мэдээний хангах бүх онцгой боломжууд хийгээд адислалуудыг Сүмийн зохистой гишүүн болгонд хүртээх хүслээр бидэнд бурханлигаар нөлөөллөө.

Биднээс өмнө хэзээ нэгэн цагт байсан бошиглогчид хийгээд Сүмийн Ерөнхийлөгчдөөр Бурханы мөнхийн төлөвлөгөөнд хийгдсэн амлалтуудыг ухамсарлан, бидний зохистой бүх ах нар санваарыг хүлээн авч болохын тулд, мөн санваар нь буцаан авагдсан тэдний итгэлтэй байдлыг гэрчлэн, бурханлиг удирдамжийн тулд Их Эзэнд даруухнаар залбиран, Ариун сүмийн Дээд өрөөнд олон цагийг өнгөрүүлэн, бидний итгэлтэй ах нар, тэдний нэрийн өмнөөс бид удаанаар мөн хичээнгүйлэн гуйлаа.

Тэрбээр бидний залбирлуудыг сонссон, мөн Сүм дэх зохистой, итгэлтэй эрэгтэй хүн бүр ариун санваарыг хүлээн авч, үүнийг бурханлиг эрх мэдлийн хүчээр хэрэглэн мөн тэндээс үүдэлтэй адислал бүрийг, түүний дотор ариун сүмийн адислалуудыг хайртай хүмүүсийнхээ хамт эдэлж болох тэрхүү эрт дээр үед амлагдсан өдөр ирлээ гэдгийг илчлэлтээр нотоллоо. Иймээс, Сүмийн бүх зохистой эрэгтэй гишүүд яс үндэс буюу арьсны өнгөнөөс үл хамааран санваарт томилогдож болно. Аароны эсвээс Мелкизедек санваар аль алинд нь томилогдох бүх нэр дэвшигчидтэй нягт хянуур ярилцлага хийх бодлогыг баримтлахдаа, зохистой байдлын тогтоосон жишгүүдийг тэд хангасныг итгэлтэйгээр тодорхойлох талаар санваартны удирдагчид зааварлагдаж байна.

Их Эзэн эдүгээ эрх мэдэл бүхий үйлчлэгчдийнхээ дуу хоолойг анхаарч, түүнчлэн сайн мэдээний адислал бүрийг хүлээн авахад өөрсдийгөө бэлтгэх дэлхий даяарх

бүх хүүхдийнхээ адислалын төлөө Өөрийн тааллыг мэдүүлснийг бид буурь суурьтайгаар тунхаглаж байна.

Чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлсэн,

СПЕНСЕР В.КИМБАЛЛ

Н.Элдон Таннер

Марион Г.Ромни

Тэргүүн Зөвлөл

Спенсер В.Кимбаллыг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Бошиглогч, үзмэрч, мөн илчлэгч, түүнчлэн ерөнхийлөгчийн хувьд хүлээн зөвшөөрч, хууль батлах, өөрчлөх эрх мэдэл бүхий хуралдайн хувьд бид энэхүү илчлэлтийг Их Эзэний үг хийгээд таалал хэмээн хүлээн авахаар санал оруулж байна. Дэмжиж байгаа бүхэн баруун гараа өргөн харуулна уу. Эсэргүүцэж байгаа хүн мөн ийм байдлаар мэдэгдэнэ үү?

Өмнөх байр суурийг дэмжих санал хураалт бүрэн нэгдмэл байдлаар батлагдав.

Юта, Солт Лейк хот, 1978 оны есдүгээр сарын 30.

Агуу ҮНЭТ Сувд

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН

ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМИЙН

АНХНЫ БОШИГЛОГЧ, ҮЗМЭРЧ МӨН ИЛЧЛЭГЧ

ИОСЕФ СМИТИЙН

ИЛЧЛЭЛТҮҮД, ОРЧУУЛГУУД МӨН ӨГҮҮЛЭМЖҮҮДЭЭС

СОНГОЖ АВСАН ЦУГЛУУЛГА ОРШВОЙ

Агуу Үнэт Сувд бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнт-
нүүдийн Сүмийн итгэл хийгээд сургаалын олон чухал
талыг хөндсөн сонгомол материалуудын цуглуулга бөлгөө.
Эдгээр зүйлүүдийг Бошиглогч Иосеф Смит боловсруулсан
бөгөөд түүний үе дэх Сүмийн тогтмол хэвлэлүүдэд нийтэлжээ.

Агуу Үнэт Сувд хэмээх нэр бүхий материалуудын анхны
цуглуулгыг Ахлагч, дараа нь Арванхоёрын Зөвлөлийн гишүүн
болсон, Британийн Номлолын ерөнхийлөгч асан Франклин
Д.Ричардс 1851 онд гаргажээ. Үүний зорилго нь Иосеф Сми-
тийн үед гаргах нь хязгаарлагдмал байсан зарим чухал
өгүүллүүдийг илүү хүртээмжтэй болгох явдал байлаа. Европ
болон Америк даяар Сүмийн гишүүнчлэл өссөн учраас, эдгээр
зүйлүүдийг хүртээмжтэй болгох шаардлага гарч ирсэн би-
лээ. Агуу Үнэт Сувд өргөнөөр хэрэглэгдэж, мөн үүнээс үүдэн
1880 оны аравдугаар сарын 10-нд Тэргүүн Зөвлөл болон Солт
Лейк Хотод болсон ерөнхий чуулганы санаачлагаар Сүмийн
жишиг бүтээл болжээ.

Сүмийн эрэлт хэрэгцээ шаардсаны дагуу агуулгад хэд
хэдэн удаа хянан засварлалт хийсэн байна. Анхны хэвлэлд
байгаагүй Мосегийн Номны хэсгүүд 1878 онд нэмэгджээ.
1902 онд Сургаал ба Гэрээнд орхигдсон зарим хэсгүүд Агуу
Үнэт Сувдад дахин хэвлэгджээ. 1902 онд зүүлт тайлбар бүхий
бүлгүүд болон шүлгүүд болгон зохион байгуулсан байна.
Анхны хэвлэл нь хоёр баганат хуудсууд, товъёогтойгоор 1921
онд гарчээ. Хоёр зүйл илчлэлт нэмэгдэж орсон 1976 оны
дөрөвдүгээр сарыг хүртэл өөр өөрчлөлтүүд хийгдээгүй
байлаа. 1979 онд хоёр зүйлийг Агуу Үнэт Сувдаас авч Сургаал
ба Гэрээнд оруулсан нь эдүгээ хэсэг 137 ба хэсэг 138 юм.
Одоогийн хэвлэлд бичвэрийг түрүү үеийн баримт бичгүүд-
тэй нийцүүлэхийн тулд зарим өөрчлөлт оруулсан болно.

Одоогийн агуулгын товч оршлыг дор харуулав:

Мосегийн номноос авсан цуглуулгууд. 1830 оны зургадугаар
сард Библийн Эхлэл номны Иосеф Смитийн орчуулгаас авсан
хэсэг (*History of the Church*, 1:98–101, 131–139).

Абрахамын ном. 1835 онд Иосеф Смитийн гарт орж ирсэн
патриарх Абрахамын бичээсүүдийг агуулсан египет хэл дээр
үйсэн дээр бичсэн зарим дурсгалаас хийсэн орчуулга. Уг ор-
чуулга нь Иллинойн Наувуд 1842 оны гуравдугаар сарын
1-нээс эхлэн *Times and Seasons*-д цувралаар нийтлэгдсэн байна
(*History of the Church*, 4:519–534).

Иосеф Смит — Матай. Библийн Иосеф Смитийн орчуулга
дахь Матайн гэрчлэлээс авсан хэсэг (Шинэ Гэрээний орчуул-
гыг эхлэх бурханлиг тушаал, Сургаал ба Гэрээ 45:60–61-ийг үз).

Иосеф Смит—Түүх. 1838 онд тэрээр бэлтгэж мөн Иллинойн Наувуд 1842 оны гуравдугаар сарын 15-наас *Times and Seasons*-д цувралаар нийтлэгдсэн Иосеф Смитийн албан ёсны гэрчлэл хийгээд түүхээс авсан хэсгүүд (*History of the Church*, 1:1–44).

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Итгэлийн Тунхаг. Вентвортын Захидал (*History of the Church*, 4:533–541) хэмээн нийтийн мэдэх Сүмийн товч түүхийн хамт 1842 оны гуравдугаар сарын 1-нд *Times and Seasons*-д нийтлэгдсэн Иосеф Смитийн мэдэгдэл оршвой.

НОМНУУДЫН НЭРС БА ДЭС ДАРААЛАЛ

	<i>Дугаар</i>
Мосегийн Номноос сонгож авсан цуглуулгууд	1
Абрахамын Ном	39
Хуулбар дугаар 1	40
Хуулбар дугаар 2	50
Хуулбар дугаар 3	57
Иосеф Смит—Матай	59
Иосеф Смит—Түүх	64
Итгэлийн Тунхаг	84

МОСЕГИЙН НОМНООС СОНГОЖ АВСАН ЦУГЛУУЛГУУД

1830 оны зургадугаар сарын 30-наас 1831 оны хоёрдугаар сард Бошиглогч Иосеф Смитэд илчлэгдсэнээр Библийн орчуулгаас авсан хэсэг оршвой.

БҮЛЭГ 1

(1830 оны зургадугаар сар)

Бурхан өөрийгөө Мосед илчлэв— Мосе хувиран өөрчлөгдөв— Тэрээр Сатантай тулгарав— Хүн суурьшсан олон дэлхийг Мосе харав— Тоо томшгүй олон дэлхий Хүүгээр бүтээгдсэн ажээ— Бурханы ажил хийгээд алдар суу нь хүмүүний үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрах явдал юм.

МОСЕ нэгэн үлэмжийн Мөндөр ууланд дээш аваачигдсан үед “Мосед ⁶хэлсэн Бурханы үгс оршвой,

2 Мөн тэрээр Бурханыг “нүүр нүүрээрээ ⁶харж, мөн тэрээр түүнтэй ярилцаж, мөн Бурханы ⁶алдар суу Мосе дээр байв; тиймийн тул Мосе түүний оршихуйд ⁶тэсч чадав.

3 Мөн Бурхан Мосед ярьж, хэлсэн нь: Болгоогтун, бибээр Их Эзэн “Бүхнийг Чадагч Бур-

хан болой, ⁶Төгсгөлгүй нь миний нэр бөлгөө; учир нь бибээр өдрүүдийн эхлэл буюу жилүүдийн төгсгөл үгүй болой; мөн энэ нь төгсгөлгүй биш гэж үү?

4 Мөн, болгоогтун, чи миний хүү билээ; иймийн тул “харагтун, мөн бибээр ⁶гарынхаа бүтээлийг чамд үзүүлье; гэвч бүгдийг нь биш, учир нь миний ⁶ажлууд, мөн тэрчлэн миний ⁶үгс ⁶төгсгөлгүй билээ, учир нь тэдгээр нь хэзээ ч зогсох нь үгүй.

5 Иймийн тул, тэрээр миний бүх алдар сууг болгоохоос өөрөөр хүмүүн миний бүх ажлыг болгоож чадах нь үгүй; мөн хүмүүн миний бүх алдар сууг болгоож, мөн хойшид маханбодид дэлхий дээр үлдэж чадах нь үгүй.

6 Мөн чамд зориулсан ажил надад буй, Мосе, хүү минь; мөн чибээр миний “Төрсөн Ганцтай ⁶адил билээ; мөнхүү

1 1a су Мосе.

б Алма 12:30;
Мосе 1:42.

2a Тоол. 12:6–8;
Дэд хууль 34:10;
С ба Г 17:1.

б Ег. 3:6; 33:11;
Иохан 1:18; 6:46;
Ифер 3:6–16;
Мосе 1:11.

исо, Ег. 33:20, 23.
в Дэд хууль 5:24;

Мосе 1:13–14, 25.

су Алдар суу.

г су Зөөгдөлт.

3a Илч. 11:17; 19:6;

1 Ниф. 1:14; 121:4.
су Бурхан, Бурхан
тэргүүтэн.

б Иса. 63:16;
С ба Г 19:9–12;

Мосе 7:35.

су Төгсгөлгүй.

4a Мосе 7:4.

б Мосе 7:32, 35–37.

в Дуул. 40:5;

С ба Г 76:114.

г 2 Ниф. 9:16;

С ба Г 1:37–39.

су Бурханы Үг.

д Дуул. 111:7–8;

Мосе 1:38.

6a су Төрсөн Ганц.

б Эхл. 1:26;

Ифер 3:14–15;

Мосе 1:13–16.

миний Төрсөн Ганц нь “Аврагч бөгөөд мөн байх болно, учир нь тэрбээр ‘ач ивээл хийгээд ^аүнэнээр дүүрэн бөлгөө; гэвч надаас өөр Бурхан ‘үгүй болой, мөн бүх зүйл надтай хамт буй, учир нь би тэдгээрийг бүгдийг нь ^бмэддэг.

7 Мөн эдүгээ, болгоогтун, энэ нэг зүйлийг би чамд үзүүлье, Моcе, хүү минь, учир нь чибээр дэлхийд байна, мөн эдүгээ би үүнийг чамд үзүүлье.

8 Мөнхүү улиран тохиох дор Моcе харж, мөн дээр нь тэрбээр бүтээгдсэн тэр “дэлхийг болгоов; мөн дэлхий хийгээд үүний хязгааруудыг, мөн байгаа мөн бүтээгдсэн байсан хүмүүний бүх үрсийг Моcе ^бболгоов; мөн үүнд тэрбээр агуу ихээр “гайхаж мөн гайхашрав.

9 Мөн Бурханы оршихуй Мосегоос татан авагдсан байв, тийнхүү түүний алдар суу Моcе дээр байсангүй; мөн Моcе өөрийнхөө байдалд үлдсэн байлаа. Мөн тэрбээр өөрийнхөө байдалд үлдэхэд тэрээр дэлхийд унав.

10 Мөнхүү улиран тохиох

дор Моcе өөрийн ердийн “хүчин чадлыг хүмүүний адилаар хүлээн авахын өмнө энэ нь олон цагийн хугацаа байлаа; мөн тэрээр өөртөө хэлжээ: Эдүгээ, энэ шалтгааны учир хүмүүн ^бюу ч биш, миний хэзээ ч төсөөлж байгаагүй тийм зүйл гэдгийг би мэднэ.

11 Харин эдүгээ миний өөрийн мэлмий “Бурханыг болгоов; гэвч миний ^бэгэл бус, харин миний сүнсний мэлмий бөлгөө, учир нь миний ердийн мэлмий болгоож чадах нь үгүй; учир нь бибээр ^бхатаж мөн түүний оршихуйд ‘нас нөгчих ёстой байв; гэвч түүний алдар суу над дээр байлаа; мөн бибээр, түүний ^анүүрийг болгоов, учир нь би түүний өмнө ^бхувирсан байв.

12 Мөнхүү улиран тохиох дор Моcе эдгээр үгсийг хэлтэл, болгоогтун, “Сатан түүнийг ^бсорихоор ирж, хэлэв: Моcе, хүний хүү, намайг шүтэгтүн.

13 Мөнхүү улиран тохиох дор Моcе Сатан уруу харж мөн хэлэв: Чи хэн бэ? Учрыг болгоогтун, түүний Төрсөн

6в су Аврагч.

г Иохан 1:14, 17;

Алма 13:9.

су Ач ивээл.

д Моcе 5:7.

е Хаад. дээд 8:60;

Иса. 45:5–18, 21–22.

ё 1 Ниф. 9:6;

2 Ниф. 9:20;

Алма 18:32;

С ба Г 38:1–2.

су Бүхнийг Мэдэгч.

8а Моcе 2:1.

б Моcе 1:27.

в Дуул. 8:3–4.

10а Дан. 10:8, 17;

1 Ниф. 17:47;

Алма 27:17;

ИС—Т 1:20.

б Дан. 4:35; Хил. 12:7.

11а су Бурхан, Бурхан тэргүүтэн.

б Моcе 6:36;

С ба Г 67:10–13.

в Ег. 19:21.

г Ег. 20:19.

д Эхл. 32:30;

Моcе 7:4.

е Мат. 17:1–8.

су Хувиралт.

12а Моcе 4:1–4.

су Чөтгөр.

б Моcе 6:49.

су Уруу татах,

Уруу таталт.

Ганцын адил Бурханы “хүү байна би; мөн бибээр чамайг шүтэх ёстой тэр алдар суу чинь хаана байна?

14 Учрыг болгоогтун, түүний алдар суу над дээр ирэхээс, мөн бибээр түүний өмнө “хувирахаас бусдаар, бибээр Бурханыг харж чадах нь үгүй, харин бибээр чамайг эгэл хүмүүндээ харж чадаж байна. Энэ нь тийм биш гэж үү, тийм биз дээ?

15 Бурханы минь нэр адислагдаг, учир нь түүний Сүнс бүгдээр надаас татагдан авагдсан нь үгүй, эсвээс чиний алдар суу өөр хаана байх билээ, учир нь надад харанхуй байна шүү дээ? Мөн бибээр Бурхан та хоёрын хооронд шүүж чадна; учир нь Бурхан надад: Бурханыг “шүт, учир нь чи гагцхүү түүнд ^бүйлчлэх ёстой хэмээн хэлсэн билээ.

16 Эндээс зайл чи, Сатан; намайг бүү мэхэл: учир нь Бурхан надад: Чибээр миний Төрсөн Ганцтай “адил хэмээн хэлсэн шүү дээ.

17 Мөн тэрбээр шатаж буй “бутан дотроос намайг дуудсан үедээ: Миний Төрсөн Ганцын нэрээр Бурханыг ^бдуудагтун, мөн намайг шүт хэмээн хэлж тэрбээр тэрчлэн надад зарлигууд өгсөн бөлгөө.

18 Мөн Мосе дахин хэлэв: Бибээр Бурханыг дуудахаа зогсох нь үгүй, түүнээс асуух бусад зүйл надад буй, учир нь түүний алдар суу над дээр байсаар байна, иймийн тул бибээр түүний болон чиний хооронд шүүж чадна. Эндээс тонил Сатан.

19 Мөн эдүгээ, эдгээр үгсийг Мосе хэлэхэд, Сатан чанга дуугаар хашгирч, мөн газарт уураа гарган тушааж, Би “Төрсөн Ганц байна, намайг шүт.

20 Мөнхүү улиран тохиох дор Мосе үлэмж ихээр айж эхлэв, мөн тэрээр айж эхлэхэд, “тамын гашууныг тэрээр харав. Гэсэн хэдий ч тэр Бурханыг ^бдуудан, хүч чадал авав, мөн тэрээр тушаан хэлэв: Надаас тонил, Сатан, учир нь алдар суугийн Бурхан болох гагцхүү энэ Бурханыг л би шүтэх болно.

21 Мөн эдүгээ “Сатан дагжин чичирч эхлэв, мөн дэлхий чичрэв; мөн Мосе хүч чадал хүлээн авч, тэгээд Бурханыг дуудан хэлэв: Төрсөн Ганцын нэрээр, эндээс тонил Сатан.

22 Мөнхүү улиран тохиох дор Сатан уйлан мөн гаслан, мөн шүдээ “хавиран чанга дуугаар хашгирав; мөн тэр эндээс, бүр Мосегийн дэргэдээс тонилов, ингэснээр тэрээр түүнийг харсан нь үгүй.

13a Дуул. 82:6;
1 Иохан 3:2;
Евр. 12:9.

14a су Зөөгдөлт.

15a Мат. 4:10.

су Шүтэн бишрэх.

б 1 Сам. 7:3;

3 Ниф. 13:24.

16a Мосе 1:6.

17a Ег. 3:2.

б Мосе 5:8.

19a Мат. 24:4–5.

20a су Там.

б ИС—Т 1:15–16.

су Залбирал.

21a су Чөтгөр.

22a Мат. 13:41–42;

Мозая 16:1–3.

23 Мөн эдүгээ энэ зүйлийн тухай Моце гэрчлэв; гэвч ёс бус явдлын улмаас энэ нь хүмүүний үрсийн дунд байсангүй.

24 Мөнхүү улиран тохиох дор Сатан Мосегийн дэргэдээс тонилоход Моце нүдээ тэнгэр өөд өргөн харж, Эцэг, Хүү хоёрын тухай гэрчилдэг “Ариун Сүнсээр дүүрсэн байлаа;

25 Мөн Бурханы нэрийг дуудан, тэрээр түүний алдар сууг дахин болгоов, учир нь энэ нь түүн дээр байлаа; мөн тэрээр: Адислагдсан болой чи, Моце, учир нь Бүхнийг Чадагч бибээр, чамайг сонгосон билээ, мөн чибээр “их уснаас илүү хүчтэй болгогдох болно; учир нь тэд чиний “зарлигийг чибээр “Бурхан лугаа адил дуулгавартай дагах болно.

26 Мөн харагтун, би чамтай бүр чиний өдрүүдийн төгсгөл хүртэл хамт байна; учир нь чи миний хүмүүсийг, бүр миний “сонгосон “Израилыг “боолчлолоос “чөлөөлөх болно.

27 Мөнхүү улиран тохиох дор, уг дуу хоолой ярьсаар байхад, Моце хараа бэлчээн мөн дэлхийг, тийм ээ, бүр үүний бүхнийг “болгоов; мөн түүний эс болгоосон үүний ямар ч өчүүхэн хэсэг тэнд бай-

сангүй, үүнийг Бурханы Сүнсээр ялган таньсан бөлгөө.

28 Мөн тэрээр тэрчлэн үүний оршин суугчдыг болгоов, мөн түүний болгоогоогүй нэг ч бодгаль тэнд байсангүй; мөн тэрбээр Бурханы Сүнсээр тэдгээрийг ялган танив; мөн тэдгээрийн тоо нь агуу, бүр далайн эрэг дээрх элс лугаа адил тоо томшгүй байв.

29 Мөн тэрбээр олон газар нутгийг болгоов; мөн газар нутаг бүр нь “дэлхий хэмээн нэрлэгдсэн байв, мөн тэдгээрийн гадаргуу дээр оршин суугчид байлаа.

30 Мөнхүү улиран тохиох дор Моце Бурханыг дуудаж хэлэв: Би танаас гуйя, эдгээр зүйлүүд яагаад ийм байгааг, мөн та тэдгээрийг юугаар хийснийг надад хэлээч?

31 Мөн болгоогтун, Их Эзний алдар суу Моце дээр байлаа, тийм болохоор Моце Бурханы оршихуйд зогсож, мөн түүнтэй “нүүр нүүрээрээ тулан ярилцаж байв. Мөн Их Эзэн Бурхан Мосед хэлэв: Миний өөрийн “зорилгын учир би эдгээр зүйлүүдийг хийсэн билээ. Энэ бол мэргэн ухаан бөгөөд энэ нь надад үлдэх болно.

32 Мөн “ач ивээл хийгээд “үнэнээр дүүрэн миний Төрсөн Ганц болох өөрийн хүч-

24a су Ариун Сүнс.
25a Ег. 14:21–22.
б су Хүч; Санваартан.
в Ег. 4:16.
26a су Сонгосон.
б Хаад. дээд 8:51–53.
су Израил.

в 1 Ниф. 17:23–25.
г Ег. 3:7–12.
27a С ба Г 88:47;
Моце 1:8.
су Үзэгдэл.
29a су Газар дэлхий.
31a Дэд хууль 5:4;

Моце 1:11.
б Иса. 45:17–18;
2 Ниф. 2:14–15.
32a Дуул. 19:1;
Моце 5:7–8.
су Ач ивээл.
б су Үнэн.

ний “үгээр би тэдгээрийг бүтээсэн юм.

33 Мөн тоо томшгүй олон “дэлхийг ^ббүтээсэн буюу би; мөн тэрчлэн өөрийн хувийн зорилгын учир тэрчлэн тэдгээрийг бүтээсэн болой би; мөн миний “Төрсөн Ганц болох Хүүгээр би тэдгээрийг бүтээлгэсэн юм.

34 Мөн “олон болох бүх хүмүүнээс ^банхны хүнийг би “Адам хэмээн нэрлэсэн бөлгөө.

35 Гэвч гагцхүү энэ дэлхийн, мөн үүний оршин суугчдын шастирыг би чамд өгье. Учрыг болгоогтун, миний үгний хүчээр алга болсон олон дэлхий буй. Мөн олон нь одоо байгаа буюу, мөн тоо томшгүй тэдгээр нь хүмүүний тулд болой; харин бүх зүйл надад тоологддог буюу, учир нь тэдгээр нь минийх бөгөөд мөн би тэдгээрийг “мэддэг.

36 Мөнхүү улиран тохиох дор Мосе Их Эзэнд ярьж, хэлэв: Ай Бурхан минь, өөрийнхөө үйлчлэгчид нигүүлсэнгүй байгаач, мөн энэ дэлхий мөн үүний оршин суугчид мөн тэрчлэн тэнгэрийн талаар надад хэлээч, мөн тэгвэл

таны үйлчлэгч сэтгэл хангалуун байх болно.

37 Мөн Их Эзэн Мосед хандан ярьж, хэлэв: “Тэнгэрүүд, тэдгээр нь олон болой, мөн тэдгээр нь хүмүүнд тоологдож болох нь үгүй; харин тэдгээр нь надад тоологддог бөлгөө, учир нь тэдгээр нь минийх.

38 Мөн нэг дэлхий алга болоход, үүний тэнгэр бүр үүнчлэн өөр нэг нь ирэх бөлгөө; мөн миний ажлуудад, мөн миний үгсэд “төгсгөл үгүй.

39 Учрыг болгоогтун, “үхэшгүй байдал хийгээд ^бмөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний “ажил мөн миний ‘алдар суу бөлгөө.

40 Мөн эдүгээ Мосе хүү минь дээр нь чиний зогсож байгаа энэ дэлхийн талаар би чамд ярих болно; мөн чи миний ярих зүйлүүдийг “бичиж авах ёстой.

41 Мөн хүмүүний үрс миний үгсийг юу ч биш мэтээр үнэлж мөн тэдгээрээс олныг нь чиний бичих тэр номноос “авах тэрхүү өдөрт, болгоогтун, чиний ^бадил өөр нэгнийг би бэлтгэх болно; мөн “тэдгээр нь хүмүүний үрсийн

32^в Иохан 1:1–4, 14;

Евр. 1:1–3;

Илч. 19:13;

Иаков 4:9;

Мосе 2:1, 5.

су Есүс Христ.

33^а Дуул. 8:3–4;

С ба Г 76:24;

Мосе 7:29–30.

^б су Бүтээх, Бүтээл.

^в Мосе 1:6.

34^а Мосе 4:26; 6:9.

^б Мосе 3:7.

^в Абр. 1:3.

су Адам.

35^а Мосе 1:6; 7:36.

су Бүхнийг Мэдэгч.

37^а Абр. 4:1.

су Тэнгэр.

38^а Мосе 1:4.

39^а су Мөнх бус, Мөнх

бус байдал.

^б су Мөнх амьдрал.

^в Ром 8:16–17;

2 Ниф. 2:14–15.

су Гэтэлгэлийн төлөвлөгөө.

^г су Алдар суу.

40^а 2 Ниф. 29:11–12.

41^а 1 Ниф. 13:23–32;

Мосе 1:23.

^б 2 Ниф. 3:7–19.

^в 1 Ниф. 13:32, 39–40;

С ба Г 9:2.

дунд, итгэх болгоны дунд дахин байх болно.

42 (Эдгээр үгс нь, нэр нь хүмүүний үрсийн дунд үл мэдэгдэх ёстой нэг ууланд Мосед “яригдсан байв. Мөн эдүгээ тэдгээр нь чамд яригдлаа. Итгэдэг тэднээс өөр хэнд ч тэдгээрийг бүү үзүүл, бүр тийм буюу. Амен.)

БҮЛЭГ 2

(1830 оны зургадугаар сараас аравдугаар сар)

Тэнгэр мөн дэлхийг Бурхан бүтээдэг — Амьдралын бүх хэлбэр бүтээгддэг — Бурхан хүнийг бий болгож мөн өөр бусад бүхний дээр эзэгнэлийг түүнд өгсөн бөлгөө.

Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Мосед ярьж, хэлсэн нь: Болгоогтун, энэ “тэнгэрийн, мөн энэ “дэлхийн талаар би чамд “илчилъе; миний хэлэх үгсийг бичигтүн. Бибээр Эхлэл мөн Төгсгөл мөн “Бүхнийг Чадагч Бурхан болой; өөрийн “Төрсөн Ганцаар эдгээр зүйлүүдийг “бүтээлгэсэн, тийм ээ, эхлэлд тэнгэрийг мөн дээр нь чиний зогсож байгаа дэлхийг бүтээсэн болой.

2 Мөн “дэлхий нь хэлбэргүй, мөн хоосон байв, мөн би гүний дээгүүр харанхуй ирэ-

хээр болгосон байв; мөн миний Сүнс усны гадаргуу дээр нүүж байлаа; учир нь бибээр Бурхан.

3 Мөн бибээр, Бурхан хэлэв: Тэнд “гэрэл байг; мөн тэнд гэрэл байлаа.

4 Мөн бибээр, Бурхан гэрлийг харав; мөн тэр “гэрэл нь сайн байлаа. Мөн бибээр, Бурхан гэрлийг харанхуйгаас салгав.

5 Мөн бибээр, Бурхан, гэрлийг Өдөр хэмээн нэрлэв; мөн харанхуйг Шөнө хэмээн би нэрлэв; мөн үүнийг би өөрийн “хүчний үгээр хийв, мөн энэ нь миний “хэлснээр хийгдсэн байлаа; мөн үдэш ба өглөө нь эхний “өдөр байв.

6 Мөн дахин, бибээр, Бурхан хэлэв: Усны дунд “мандал байг, мөн энэ нь үүнчлэн бүр миний хэлснээр байв; мөн би хэлэв: Уснууд нь уснуудаас салаг; мөн энэ нь хийгдсэн байлаа;

7 Мөн бибээр, Бурхан, мандлыг хийж мөн “уснуудыг, тийм ээ уг мандлын доорх агуу их уснуудыг уг мандлын дор байсан уснуудаас салгав, мөн энэ нь бүр миний хэлсэнчлэн байлаа.

8 Мөн бибээр, Бурхан, уг мандлыг “Тэнгэр хэмээн нэрлэв; мөн үдэш болон өглөө нь хоёр дахь өдөр байв.

42a Моисе 1:1.

2 1a су Тэнгэр.

б Моисе 1:8.

в Моисе 1:30, 36.

г су Бурхан, Бурхан тэргүүтэн—Эцэг Бурхан.

д су Төрсөн Ганц.

е су Бүтээх, Бүтээл.

2a Эхл. 1:2; Абр. 4:2.

3a С ба Г 88:6–13.

су Гэрэл, Христийн гэрэл.

4a Эхл. 1:4; Абр. 4:4.

5a Моисе 1:32.

б 2 Кор. 4:6.

в Эхл. 1:5.

6a Эхл. 1:6–8.

7a Абр. 4:9–10.

8a су Тэнгэр.

9 Мөн бибээр, Бурхан хэлэв: Тэнгэрийн доорх уснууд нь “нэг газарт хамтдаа цуглагдаг, мөн энэ нь үүнчлэн байв; мөн Бибээр, Бурхан хэлэв; Тэнд хуурай газар байг; мөн энэ нь үүнчлэн байв.

10 Мөн бибээр, Бурхан хуурай газрыг “Дэлхий хэмээн нэрлэв, мөн уснуудыг хамтад нь цуглуулсныг би Далай хэмээн нэрлэв; мөн бибээр, Бурхан, хийсэн бүх зүйлээ сайн байсныг харав.

11 Мөн бибээр, Бурхан хэлэв; үрийг гаргагч “өвс, өөрийнх нь төрөлтэй адилхан, үр нь өөртөө байх ёстой ургамал, жимсийг гаргагч жимсний модыг дэлхий урагш авчраг, мөн энэ нь үүнчлэн бүр миний хэлснээр байв.

12 Мөн дэлхий нь өөрийнхөө төрөлтэй адилхан, үр нь өөртөө байх ёстой үрийг гаргагч өвс, ургамал бүрийг, мөн жимс гаргагч модыг урагш авчрав; мөн бибээр, Бурхан хийсэн бүх зүйлээ сайн байсныг харав;

13 Мөн уг үдэш болон өглөө нь гурав дахь өдөр байв.

14 Мөн бибээр, Бурхан хэлэв: Шөнөөс өдрийг салгахын тулд тэнгэрийн мандалд гэрлүүд байг, мөн тэдгээр нь тэмдгүүдийн тулд, мөн улирлуудын тулд, мөн өдрүүдийн тулд, мөн жилүүдийн тулд байг;

15 Мөн тэдгээр нь дэлхийд гэрэл өгөх гэрлүүдийн тулд

тэнгэрийн мандалд байг; мөн энэ нь үүнчлэн байв.

16 Мөн бибээр, Бурхан хоёр агуу “гэрэл, өдрийг захирах илүү бага гэрлийг хийсэн бөлгөө; илүү агуу гэрэл нь нар байв, мөн илүү бага гэрэл нь сар байв, мөн тэрчлэн одод нь бүр миний үгийн дагуу хийгдсэн билээ.

17 Мөн бибээр, Бурхан дэлхийд гэрэл өгөхийн тулд тэдгээрийг тэнгэрийн мандалд тавьсан юм,

18 Мөн нар нь өдрийг захирах, мөн сар нь шөнийг захирах, мөн гэрлийг харанхуйгаас салгахын тулд болой; мөн бибээр, Бурхан, хийсэн бүх зүйлээ сайн байсныг харав;

19 Мөн үдэш болж өглөө нь дөрөв дэх өдөр байлаа.

20 Мөн бибээр, Бурхан хэлэв: Уснууд нь амьдардаг хөдөлдөг зүйлийг элбэг дэлбэгээр, мөн дэлхий дээгүүр тэнгэрийн задгай мандалд нисч болох жигүүртнүүдийг урагш авчраг.

21 Мөн бибээр, Бурхан агуу “халимнууд, мөн уснууд элбэг дэлбэгээр урагш авчирсан өөрсдийнхөө төрөлтэй адилхан, хөдөлдөг амьдрагч бүхнийг, мөн өөрийнх нь төрлөөр далавчит жигүүртэн бүрийг бүтээсэн бөлгөө; мөн бибээр, Бурхан бүтээсэн бүх зүйлээ сайн байсныг харав.

22 Мөн бибээр, Бурхан тэдгээрийг адисалж, хэлэв: Үртэй

жимстэй байгтун, мөн “өсөн үржтүгэй, мөн далай дахь уснуудыг дүүргэгтүн; мөн жигүүртнүүд дэлхийд өсөн үржиг;

23 Мөн үдэш болон өглөө нь тав дахь өдөр байв.

24 Мөн бибээр, Бурхан хэлэв: Өөрсдийнхөө төрлөөр амьдардаг зүйлийг, мал адгуус, мөлхөгч зүйлүүд мөн газрын амьтдыг өөрсдийнх нь төрлөөр дэлхий урагш авчраг, мөн энэ нь үүнчлэн байв;

25 Мөн бибээр, Бурхан газрын араатнуудыг өөрсдийнх нь төрлөөр, мөн мал адгуусыг өөрсдийнх нь төрлөөр, дэлхий дээгүүр мөлхдөг бүхнийг өөрийнх нь төрлөөр бий болгосон бөлгөө; мөн бибээр, Бурхан эдгээр бүх зүйл сайн байсныг харав.

26 Мөн бибээр, Бурхан эхлээс надтай хамт байгаа, өөрийн “Төрсөн Ганцад хэлэв: Өөрсдийн дүр төрхөөр, өөрсдийн адил төсөөр хүмүүнийг “хийцгээе; мөн энэ нь үүнчлэн болов. Мөн бибээр, Бурхан хэлэв: Далайд загаснууд, мөн агаарын жигүүртнүүд, мөн мал адгуус мөн бүх дэлхий, мөн дэлхий дээгүүр мөлхдөг мөлхөгч бүх зүйлийн дээр тэд ноёрхог.

27 Мөн бибээр, “Бурхан өөрийн дүр төрхөөр хүмүүнийг

бүтээв, өөрийн Төрсөн Ганцын дүр төрхөөр би түүнийг бүтээв; мөн эрэгтэй болон эмэгтэй тэднийг бибээр бүтээсэн бууу.

28 Мөн бибээр, Бурхан тэднийг адисалж, мөн тэдэнд хэлэв: Үр жимстэй байгтун, мөн “өсөн үржиж, мөн дэлхийг бүрхтүгэй, мөн үүнийг захирч, мөн далайн загас, агаарын жигүүртэн, мөн газар дэлхий дээр хөдлөн явдаг амьдрагч зүйл бүхний дээр эзэгнэлтэй байгтун.

29 Мөн бибээр, Бурхан хүмүүнд хэлэв: Болгоогтун, бүх дэлхийн гадаргуу дээр байдаг үр өгөгч ургамал бүрийг би чамд өглөө, мөн мод болгон нь үр өгөгч жимстэй мод байх болно; эдгээр нь та нарт “хоол хүнсний тулд байх болно.

30 Мөн бибээр амьдралыг нь соёрхсон дэлхийн амьтан болгонд, агаарын жигүүртэн болгонд, дэлхий дээгүүр мөлхөгч бүхэнд, хоол хүнсний тулд цэвэр ургамал бүхэн өгөгдөх болно; мөн энэ нь үүнчлэн, бүр миний хэлснээр байв.

31 Мөн бибээр, Бурхан хийсэн бүхнээ харав, мөн болгоогтун, миний хийсэн бүх зүйл маш “сайн байлаа; мөн үдэш хийгээд өглөө нь “зургаа дахь өдөр байв.

22a Эхл. 1:22–25;

Абр. 4:22–25.

26a су Есүс Христ.

б Эхл. 1:26–27;

Моисе 6:8–10;

Абр. 4:26–27.

в су Бүтээх, Бүтээл.

г Эхл. 1:28;

Моисе 5:1;

Абр. 4:28.

27a су Бурхан, Бурхан тэргүүтэн.

28a Моисе 5:2.

29a Эхл. 1:29–30;

Абр. 4:29–30.

31a Эхл. 1:31;

С ба Г 59:16–20.

б Ег. 20:11;

Абр. 4:31.

БҮЛЭГ 3

(1830 оны зургадугаар сараас — аравдугаар сар)

Бурхан бүх зүйлийг дэлхий дээр жам ёсоороо байхаас нь өмнө сүнс байдлаар бүтээжээ — Тэрбээр дэлхий дээрх анхны маханбодь, хүмүүнийг бүтээв — Эмэгтэй хүн эрэгтэй хүнд туслагч бөлгөө.

Тийнхүү тэнгэр хийгээд дэлхий “дууссан байлаа, мөн тэдгээрийн бүх ^болон нь буюу.

2 Мөн долоо дахь өдөр, Бурхан, бибээр ажлаа, мөн хийсэн бүх зүйлээ төгсгөл болгов; мөн бибээр “долоо дахь өдөр бүх ажлаасаа ^бамрав, мөн миний хийсэн бүх зүйл дуусав, мөн бибээр, Бурхан тэдгээр нь сайн байсныг харлаа;

3 Мөн бибээр, Бурхан долоо дахь өдрийг “адисалж мөн үүнийг ариусгав; учир юун гэвэл үүнд бибээр, Бурхан бүтээж мөн хийсэн бүх ^бажлаасаа амарсан бөлгөө.

4 Мөн эдүгээ, болгоогтун, би чамд хэлж байна, эдгээр нь бибээр, Их Эзэн тэнгэр хийгээд дэлхийг бий болгосон тэр өдөр тэд бүтээгдсэн

тэнгэрийн хийгээд дэлхийн үеийнхэн болой,

5 Мөн үүний өмнө талбайн ургамал бүхэн дэлхийд байхаасаа “өмнө, мөн талбайн ургамал бүхэн ургахаасаа өмнө буюу. Учир нь Их Эзэн бибээр, өөрийн ярьсан бүх зүйлийг дэлхийн гадаргуу дээр жам ёсоороо байхаас нь өмнө ^бсүнслэг хэлбэрээр “бүтээсэн билээ. Учир нь Их Эзэн бибээр, Бурхан, хүмүүний бүх үрсийг ^гбүтээсэн юм; мөн ^дгазар боловсруулахын тулд хараахан хүмүүнийг бус буюу; учир нь “тэнгэрт би тэднийг ^ебүтээсэн юм; мөн тэгэхэд дэлхий дээр мөн уснууд хийгээд агаарт махан бодь хараахан байгаагүй билээ;

6 Харин Их Эзэн бибээр, Бурхан ярьж мөн дэлхийгээс “манан будан хөөрч, мөн газрын бүх гадаргууг усалсан юм.

7 Мөн Их Эзэн Бурхан бибээр, хүнийг газрын “тоосноос үүсгэв, мөн амин амьсгалыг нь түүний хамрын нүхэнд оруулав; мөн ^бхүн нь дэлхий дээрх “анхны махан бодь, амьд ^гбодгаль, тэрчлэн анхны хүн болов; гэсэн хэдий ч, бүх зүйл өмнө нь бүтээгдсэн байлаа; харин тэдгээр нь

3 1а су Бүтээх, Бүтээл.
б Эхл. 2:1; Абр. 5:1.

2а су Хүндэтгэлийн өдөр.

б Эхл. 2:2-3;
Абр. 5:2-3.
су Амрах.

3а Мозай 13:19.
б Ег. 31:14-15.

5а Эхл. 2:4-5;

Абр. 5:4-5.

б Абр. 3:23;
С ба Г 29:31-34.

су Сүнсний бүтээл.

в Моисе 6:51.

г су Сүнс.

д Эхл. 2:5.

е су Тэнгэр.

ё су Хүмүүн,

Хүмүүс—Хүн,

Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүд.

6а Эхл. 2:6.

7а Эхл. 2:7;

Моисе 4:25; 6:59;

Абр. 5:7.

б су Адам.

в Моисе 1:34.

г су Бие.

сүнс байдлаар бүтээгдэж мөн миний үгийн дагуу бий болгогдсон юм.

8 Мөн Их Эзэн бибээр, Бурхан “Еденд зүүн талд цэцэрлэг суулгаж, мөн тэнд өөрийн бий болгосон хүнийг тавьсан бөлгөө.

9 Мөн уг газраас Их Эзэн бибээр мод болгоныг, жам ёсоор нь ургуулах болой, тэр нь хүмүүний хараанд аятай сайхан байх болно; мөн хүмүүн үүнийг болгоож чадах нь үгүй. Мөн энэ нь тэрчлэн амьд бодгаль болсон юм. Учир нь үүнийг би бүтээсэн тэр өдөр энэ нь сүнс байдалтай байв; учир нь бибээр, Бурхан үүнийг, тийм ээ, бүр хүмүүн хэрэглэхийн тулд миний бэлтгэсэн бүх зүйлийн хүрээнд энэ нь үлдэх бөлгөө; мөн энэ нь хоол хүнсний тулд сайн байсныг хүмүүн харав. Мөн бибээр, Их Эзэн Бурхан уг цэцэрлэгийн гол дунд амьдралын “модыг, мөн тэрчлэн сайн ба муугийн мэдлэгийн ^бмодыг тарьсан билээ.

10 Мөн Их Эзэн бибээр, Бурхан, Еденээс гол урсч цэцэрлэгийг услахаар болгосон бөлгөө; мөн тэндээс энэ нь салаалж, мөн голын дөрвөн “эх болдог байв.

11 Мөн Их Эзэн бибээр эхнийх нь нэрийг Пишон хэмээв, мөн энэ нь Их Эзэн

бибээр маш их алт бүтээсэн Хавилагийн нийт нутгаар хөндлөн гулд урсдаг;

12 Мөн тэр газрын алт шижир байв, мөн тэнд бделлиум хийгээд оникс чулуу байв.

13 Мөн хоёр дахь голын нэрийг Гихон гэдэг байв, мөн энэ нь Етиопийн нийт нутгаар хөндлөн гулд урсдаг буюу.

14 Мөн гурав дахь голын нэр нь Ассирын зүүн тийш урсдаг Хиддекел байв, мөн дөрөв дэх гол нь Евфрат байв.

15 Мөн Их Эзэн бибээр, хүнийг авч, мөн түүнийг Еденийн цэцэрлэгт, үүнийг арчилж тордон мөн үүнийг сахьж байхын тулд байрлуулсан буюу.

16 Мөн бибээр Их Эзэн Бурхан уг хүнд зарлиглан, хэлэв: цэцэрлэгийн мод болгоноос чи чөлөөтэйгөөр идэж болно,

17 Харин сайн ба муугийн мэдлэгийн модноос чи идэж болохгүй, гэсэн хэдий ч, өөрийнхөө төлөө “сонгож болно, учир нь энэ нь чамд өгөгдсөн билээ; Харин, үүнийг би хориглосныг санагтун; учир нь түүнээс идсэн тэр ^бөдөртөө чи гарцаагүй “үхэх болно.

18 Мөн хүн ганцаар байх нь сайн биш хэмээн Их Эзэн бибээр өөрийн “Төрсөн Ганцад хэлэв; иймийн тул би түүнд

8a су Еден.
9a су Амьдралын мод.
б Эхл. 2:9.
10a Эхл. 2:10.

17a Моcе 7:32.
су Сонгох эрх.
б Абp. 5:13.
в Эхл. 2:17.

су Биеийн үхэл;
Мөнх бус, Мөнх бус
байдал.
18a су Төрсөн Ганц.

зориулж ^бтуслагчийг хийх болно.

19 Мөн Их Эзэн бибээр газраас, хээрийн амьтан болгоныг, мөн агаарын жигүүртэн бүрийг бий болгов; мөн тэдгээр нь Адамд очин тэрээр тэдгээрийг юу гэж нэрлэхийг харах ёстой хэмээн зарлиглав; мөн тэдгээр нь тэрчлэн амьд бодгалиуд байлаа; учир нь бибээр, Бурхан амин амьсгалыг нь тэдэнд оруулж, мөн амьдардаг болгоныг Адам юу гэж нэрлэнэв, тэр нь тэдгээрийн нэр байх ёстой хэмээн зарлигласан бөлгөө.

20 Мөн бүх мал адгуус, мөн агаарын жигүүртнүүд, мөн хээрийн амьтан болгонд Адам нэр өгөв; харин Адамын хувьд түүнд туслагч байхгүй байлаа.

21 Мөн Бурхан Их Эзэн бибээр Адамын дээр гүн нойрсолт байхаар болгов; мөн тэрээр нойрсов, мөн би түүний хавиргануудаас нэгийг авч мөн үүний оронд махаар таглав;

22 Мөн Их Эзэн бибээр хүнээс авсан хавиргаар “эмэгтэй хүнийг хийж, мөн түүнийг эрэгтэй хүнд авчирч өгөв.

23 Мөн Адам хэлэв. Энэ нь миний яснуудын яс мөн махны минь “мах болохыг би эдүгээ мэдэв; тэрээр Эмэгтэй хүн хэмээн нэрлэгдэх болно,

учир нь тэрээр эрэгтэй хүнээс тасдан авагдсан бөлгөө.

24 Тиймийн тул эр хүн өөрийн эцэг мөн эхээ орхин, мөн эхнэртэйгээ “нэгдэн нийлэх болно; мөн тэд ^бнэг махан бодь байх болно.

25 Мөн эр хүн хийгээд түүний эхнэр хоёул нүцгэн байв, мөн тэд ичдэггүй байлаа.

БҮЛЭГ 4

(1830 оны зургадугаар сараас аравдугаар сар)

Сатан хэрхэн чөтгөр болсон нь — Тэр Еваг уруу татав — Адам Ева хоёр унав, тийнхүү үхэл дэлхийд ирэв.

Мөн Их Эзэн Бибээр, Бурхан Мосед ярьж, хэлэв: Миний Төрсөн Ганцын нэрээр чиний зарлигласан тэр “Сатан, мөн адил ^бэхлэлээс байгаа бөлгөө, мөн тэрээр миний өмнө ирж, хэлэв, — Болгоогтун, би энд байна, намайг илгээгтүн, би таны хүү байх болно, мөн нэг ч бодгаль хаягдахгүйгээр бибээр хүн төрөлхтнийг гэтэлгэх болно, мөн үүнийг ^бби гарцаагүй хийх болно, иймийн тулд өөрийн алдар хүндэтгэлийг надад өгөгтүн.

2 Гэвч, болгоогтун, миний Хайрт мөн эхлэлээс “Сонгогдсон Хайрт ^бХүү минь, надад хэлэв — “Аав аа, таны ‘таалал

18б Эхл. 2:18; Абр. 5:14.

22а су Ева; Эмэгтэй, Эмэгтэйчүүд.

23а Эхл. 2:23; Абр. 5:17.

24а Эхл. 2:24;

С ба Г 42:22;

49:15–16;

Абр. 5:17–18.

б су Гэрлэлт, Гэрлэх.

4 1а су Чөтгөр.

б С ба Г 29:36–37.

в Иса. 14:12–15.

2а Моисе 7:39; Абр. 3:27.

су Урьдчилсан

томилолт.

б су Есүс Христ.

в су Бурхан, Бурхан тэргүүтэн — Эцэг Бурхан.

г Лук 22:42.

хэрэгжих болно, мөн ^аалдар суу үүрд таных байх болно.

3 Иймийн тул, Сатан миний “эсрэг бослого гаргасан хийгээд бибээр Их Эзэн, Бурхан, мөн тэрчлэн түүнд өгсөн хүмүүний ^бсонгох эрхийг эрэлхийлэн мөн би түүнд өөрийн хүчийг өгөх ёстой гэсний учир түүнийг би Төрсөн Ганцынхаа хүчээр доош “хаягдахаар болгосон бөлгөө;

4 Мөн тэрээр Сатан, тийм ээ, бүр чөтгөр, хүмүүнийг мэхлэн мөн харалган болгох, мөн тэднийг, бүр миний дуу хоолойг үл сонсох болгоныг таалалдаа боолчлон хөтлөх бүх “худал хуурмагийн эцэг болсон билээ.

5 Мөн эдүгээ Их Эзэн Бурхан миний хийсэн хээрийн ямар ч амьтнаас илүү “зальтай нь хорт могой байв.

6 Мөн Сатан үүнийг хорт могойн зүрхэнд хийн (учир нь тэрээр олныг араасаа дагуулсан буюу) мөн тэрээр тэрчлэн “Еваг мэхлэхийг эрэлхийлсэн ажгуу, учир нь тэрээр Бурханы оюуныг мэдсэнгүй, иймийн тул тэрээр дэлхийг устгахыг эрэлхийлж байв.

7 Мөн тэрээр эмэгтэй хүнд хэлэв: Тийм ээ, та нар “цэцэрлэгийн мод бүрээс идэж болохгүй хэмээн Бурхан хэлсэн

биз дээ? (Мөн тэрээр хорт могойн амаар ярьж байв.)

8 Мөн эмэгтэй хүн хорт могойд хэлэв: Бид цэцэрлэгийн моднуудын жимснээс идэж болно;

9 Харин цэцэрлэгийн гол дунд чиний болгоож буй тэр модны жимсний тухай, Бурхан — Та нар үүнээс идэх ёсгүй, та нар үхэхгүйн тулд, үүнд хүрэх ч ёсгүй хэмээн хэлсэн шүү дээ.

10 Мөн хорт могой эмэгтэй хүнд хэлэв: Чи гарцаагүй үхэхгүй ээ;

11 Учир нь та нар үүнээс идсэн тэр өдөр, тийнхүү та нарын “нүд нээгдэх болно, мөн сайн ба мууг ^бмэдсэнээр та нар бурхад шиг болох болно гэдгийг Бурхан мэддэг.

12 Мөн тэгээд эмэгтэй хүн уг мод хүнсний тул сайн байсныг харахад мөн энэ нь түүнийг нүдэнд тааламжтай байв, мөн мод нь түүнийг мэргэн болгохыг “хүсч, тэрээр үүний жимснээс авч, мөн ^бидэв, мөн тэрчлэн нөхөртөө өгөв, мөн тэр идсэн ажээ.

13 Мөн тэдний хоёулангийнх нь нүд нээгдэж, мөн тэд “нүцгэн байгаагаа мэдэв. Мөн тэд инжийн навчнуудыг цуглуулан зүйж мөн өөрсдөдөө хормогч хийв.

14 Мөн тэд цэцэрлэг дун-

2д су Алдар суу.
3а су Тэнгэр дэх Зөвлөл.
б су Сонгох эрх.
в С ба Г 76:25–27.
4а 2 Ниф. 2:18;
С ба Г 10:25.

су Заль, Залилах, Залилан; Худал хэлэх.
5а Эхл. 3:1; Мозая 16:3; Алма 12:4.
6а су Ева.
7а су Еден.

11а Эхл. 3:3–6;
Моcе 5:10.
б Алма 12:31.
12а Эхл. 3:6.
б су Адам, Ева хоёрын уналт.
13а Эхл. 2:25.

дуур өдрийн сэрүүнд “алхаж явахдаа Их Эзэн Бурханы дуу хоолойг сонсов; мөн Адам болон түүний эхнэр, Их Эзэн Бурханы дэргэдээс өөрсдийгөө нуухын тулд цэцэрлэгийн моднуудын дунд оров.

15 Мөн Их Эзэн бибээр, Бурхан, Адамыг дуудаж, мөн түүнд хэлэв: Чи “хааччихав аа?

16 Мөн тэрээр хэлэв: Би цэцэрлэгт таны дуу хоолойг сонсоод мөн бибээр айсан буюу, учир нь өөрийгөө нүцгэн байгааг хараад, мөн би өөрийгөө нуусан бөлгөө.

17 Мөн бибээр Их Эзэн, Бурхан Адамд хэлэв: Чамайг нүцгэн байна гэж хэн чамд хэлэв? Чи идэх ёсгүй, хэрэв идэх аваас чи гарцаагүй “үхнэ хэмээн чамд миний зарлигласан тэр модноос чи идсэн үү?

18 Мөн эрэгтэй хүн хэлэв: Надад таны өгч, мөн тэрээр надтай хамт үлдэх ёстой хэмээн зарлигласан тэр эмэгтэй, тэр чинь уг модны жимснээс надад өгч тэгээд би идсэн.

19 Мөн Их Эзэн бибээр, Бурхан, эмэгтэй хүнд хэлэв: Чи чинь юу хийчих нь энэ вэ? Мөн тэр эмэгтэй хэлэв: Хорт могой намайг “мэхэлж, тэгээд би идчихсэн.

20 Мөн Их Эзэн бибээр, Бурхан хорт могойд хэлэв: Чи үүнийг хийсэн учир бүх амьтдаас мөн хээрийн амьтан болгоноос илүүгээр “зүхэгдэх

болно, чи хэвлийгээрээ мөлхөж мөн амьдралынхаа бүх өдрүүдэд тоос идэх болно;

21 Мөн эмэгтэй та хоёрын хооронд, чиний үрс хийгээд түүний үрсийн хооронд би өс хонзон тавих болно, мөн тэрээр чиний толгойг няцлах болно мөн чи түүний өсгийг няцлах болно.

22 Бибээр, Их Эзэн, Бурхан эмэгтэйд хэлэв: Би чиний “зовлон мөн чиний жирэмсний зовиурыг үлэмж ихээр өсгөн нэмэх болно. Чи зовлонд хүүхдүүдийг урагш авчирч мөн хүсэл чинь нөхөрт чинь байх болно, мөн тэрээр чамайг захирах болно.

23 Мөн Их Эзэн, Бурхан бибээр Адамд хэлэв: Чи эхнэрийнхээ дуу хоолойг анхаарч мөн — Чи үүнээс идэх ёсгүй хэмээн хэлж, чамд миний зарлигласан модны жимснээс идсэн учир, чамаас болж газар зүхэгдэх болно, мөн чи үүнээс амьдралынхаа бүх өдрүүдэд зовлонд идэх болно.

24 Өргөс тэрчлэн, мөн өргөст халгайг энэ нь чамд урагш авчрах болно, мөн чи талбайн ургамал идэх болно.

25 Чи газарт эргэж ирэх хүртлээ нүүрнийхээ “хөлсөөр талхаа олж идэх болно — учир нь чи үүнээс авагдсан бөлгөө, мөн чи тоос байсан бөгөөд мөн чи ⁶тоосондоо буцаж очих болно.

26 Мөн Адам эхнэрийнхээ

14a Эхл. 3:8.
15a Эхл. 3:9.
17a Мосе 3:17.
19a Эхл. 3:13;

Мозая 16:3.
20a Эхл. 3:13–15.
22a Эхл. 3:16.
25a Эхл. 3:17–19.

су Адам, Ева
хоёрын уналт.
6 Эхл. 2:7; Мосе 6:59;
Абр. 5:7.

нэрийг Ева хэмээв, учир нь тэрээр амьд бүхний эх байв, учир нь ийн бибээр, Их Эзэн, Бурхан “олон байгаа бүх эмэгтэйчүүдээс эхнийх нь хэмээн нэрлэв.

27 Адамд мөн тэрчлэн түүний эхнэрт бибээр Их Эзэн, Бурхан арьсан хувцас хийж, мөн тэднийг “хувцаслав.

28 Мөн бибээр, Их Эзэн, Бурхан өөрийн Төрсөн Ганцад хэлэв: Болгоогтун, “хүн сайн ба мууг ^бмэдсэнээр бидний нэгэн болгогдов, мөн эдүгээ тэрээр гараа урагш сунгаж мөн амьдралын ^бмодноос тэрчлэн бас ^бхүртэж мөн үүрд амьдрахгүйн тулд,

29 Тиймийн тул, бибээр, Их Эзэн, Бурхан түүнийг авсан тэрхүү газрыг боловсруулахын тулд түүнийг “Еденийн Цэцэрлэгээс явуулах болно;

30 Учир нь бибээр, Их Эзэн, Бурхан амьдардгийн адил, бүр үүнчлэн миний “үгс хий хоосон буцаж үл болох бөлгөө, учир нь тэдгээр нь миний амнаас гарсан л бол тэдгээр нь биелэгдэх ёстой.

31 Иймээс бибээр хүнийг хөөж, мөн амьдралын модны замыг хамгаалахын тулд зүг бүрд эргэлдэгч “херибум болон галт илдийг Еденийн Цэцэрлэгийн зүүн талд байрлуулсан бөлгөө.

32 (Мөн эдгээр нь өөрийн үйлчлэгч Мосед миний ярьсан үгс болой, мөн тэдгээр нь би байдгийн адил үнэн бөлгөө, мөн тэдгээрийг би та нарт ярилаа. Намайг зарлиглах хүртэл, итгэдэг тэдэнд бус бол, тэдгээрийг чи хүмүүнд үл үзүүлэхийг мэдтүгэй. Амен.)

БҮЛЭГ 5

(1830 оны зургадугаар сараас — аравдугаар сар)

Адам Ева хоёр хүүхдүүдийг урагш авчрав—Адам тахил өргөж мөн Бурханд үйлчлэв—Каин Абел хоёр төрөв—Каин эсэргүүцэн босч, Сатанд Бурханаас илүү хайртай байж, мөн Мөхөл болов—Аллага хийгээд ёс бус явдал газар авав—Сайн мэдээ эхлэлээс номлогдов.

Мөнхүү улиран тохиох дор, бибээр, Их Эзэн, Бурхан тэднийг хөөсний дараа Их Эзэн түүнд зарлигласанчлан, мөн тэжээмэл бүх амьтдын дээр “эзэгнэлтэй байж, мөн духныхаа хөлсийг дуслуулан байж талхаа олж идэхийн тулд Адам газар боловсруулж эхлэв.

2 Мөн Адам эхнэртэйгээ унтаж, мөн тэр түүнд хөвгүүд мөн “охидыг ^бтөрүүлэв, мөн

26a Моце 1:34; 6:9.

27a су Төлөв зан.

28a Эхл. 3:22.

су Хүмүүн,
Хүмүүс—Хүн,
Тэнгэрлэг Эцэгтэй
адил болох боломж.

б су Мэдлэг.

в Эхл. 2:9;

1 Ниф. 11:25;

Моце 3:9.

су Амьдралын мод.

г Алма 42:4–5.

29a су Еден.

30a Хаад. дээд 8:56;

С ба Г 1:38.

31a Алма 42:3.

су Херибум.

5 1a Моце 2:26.

2a С ба Г 138:39.

б Эхл. 5:4.

тэд “өсөн үржиж, мөн дэлхийг дүүргэж эхлэв.

3 Мөн тэр цагаас хойш, Адамын хөвгүүд хийгээд “охид газар нутагт хоёр хоёроороо хуваагдан, газар боловсруулж, мөн мал өсгөж эхлэв, мөн тэд тэрчлэн хөвгүүд хийгээд охидыг төрүүлэв.

4 Мөн Адам мөн түүний эхнэр Ева Их Эзэний нэрийг дуудав, мөн тэдэнд хандан өгүүлэх Их Эзэний дуу хоолойг “Еденийн Цэцэрлэг уруу хөтлөх замаас тэд сонсов, мөн тэд түүнийг харсангүй, учир нь тэд түүний ⁶оршихуйгаас таслагдсан байлаа.

5 Мөн тэд өөрсдийн Бурхан Их Эзэнийг “шүтэх ёстой, мөн мал сүргийнхээ ⁶ууган төлүүдийг Их Эзэнд барих өргөлийн тулд өргөж байх ёстой хэмээх зарлигуудыг тэрбээр тэдэнд өгчээ. Мөн Адам Их Эзэний зарлигуудад “дуулгавартай байв.

6 Мөн олон өдрийн дараа Их Эзэний “тэнгэр элч Адам дээр хүрч ирэн хэлэв: Чи яагаад Их Эзэнд ⁶тахил өргөх болов? Мөн Адам түүнд хэ-

лэв: Их Эзэн зарлигласнаас өөрийг би мэдэх нь үгүй.

7 Мөн тэгээд тэрхүү тэнгэр элч ярьж, хэлэв: Энэ зүйл бол “ач ивээл хийгээд үнэнээр дүүрэн болох Эцэгийн Төрсөн Ганцын ⁶золиослолтой “төстэй бөлгөө.

8 Иймийн тул, чи өөрийн хийх бүхнийг чи Хүүгийн “нэрээр хийх ёстой, мөн чи ⁶наманчилж, үүрд мөнхөд Хүүгийн нэрээр Бурханыг “дуудах ёстой.

9 Мөн тэр өдөр Эцэг, Хүү хоёрын тухай гэрчилдэг “Ариун Сүнс Адам дээр бууж ирэн, хэлэв: Бибээр эхлэлээс, үүнээс хойш мөн үүрд Эцэгийн ⁶Төрсөн Ганц билээ, “унасан болохоор чи, мөн бүх хүн төрөлхтөн, бүр хүссэн болгон нь “гэтэлгэгдэж болох буюу.

10 Мөн тэр өдөр Адам Бурханыг магтан дуулж мөн “дүүргэгдсэн байв, мөн дэлхийн бүх гэр бүлийн талаар ⁶бошиглож эхлэн хэлэв: Бурханы нэр адислагдаг, учир нь миний зөрчлийн улмаас нүд минь нээгдсэн буюу, мөн

2в Эхл. 1:28; Моисе 2:28.

3а Моисе 5:28.

4а су Еден.

б Алма 42:9.

5а су Шүтэн бишрэх.

б Ег. 13:12–13;

Тоол. 18:17;

Мозая 2:3.

су Ууган.

в су Дуулгавартай байх, Дуулгавартай, Дуулгавартай дагах.

6а су Тэнгэр элчүүд.

б су Золиослол.

7а Моисе 1:6, 32.

су Ач ивээл.

б Алма 34:10–15.

су Цус.

в су Есүс Христ—

Есүс Христийн

Бэлэгдэл болон хэв шинж.

8а 2 Ниф. 31:21.

б Моисе 6:57.

су Наманчлах, Наманчлал.

в су Залбирал.

9а су Ариун Сүнс.

б су Есүс Христ;

Цорын Ганц.

в су Сүнсний үхэл; Адам, Ева хоёрын уналт.

г Мозая 27:24–26;

С ба Г 93:38; ИТ 3.

су Гэтэлгэлийн төлөвлөгөө; Гэтэлгэх, Гэтэлгэгдэх,

Гэтэлгэл.

10а су Дахин төрөх, Бурханаас төрөх.

б С ба Г 107:41–56.

су Бошиглох, Бошиглол.

энэ амьдралд би “баяр хөөртэй байх болно, мөн ‘махан бодид бибээр Бурханыг дахин харах болно.

11 Мөн түүний эхнэр “Ева эдгээр бүх зүйлийг сонсоод мөн баяртай байж хэлэв: Хэрэв бидний зөрчил байгаагүй сэн бол бид хэзээ ч “үр удамгүй байх байсан, мөн сайн ба мууг, мөн бидний гэтэлгэлийн баяр баясгаланг, мөн дуулгавартай бүгдэд Бурханы өгсөн мөнх амьдралыг бид хэзээ ч мэдэхгүй байх байсан.

12 Мөн Адам, Ева хоёр Бурханы нэрийг магтан дуулав, мөн тэд бүх зүйлийг хөвгүүд болоод охиддоо “мэдүүлэв.

13 Мөн “Сатан тэдний дунд ирж, хэлэв: Би ч бас Бурханы хүү бөлгөө; мөн тэрээр тэдэнд тушаан хэлэв: Үүнд бүү итгэ; мөн тэд үүнд “итгэсэнгүй, мөн тэд Сатаныг Бурханаас илүү “хайрлав. Мөн хүмүүн тэр үеэс хойш “зуурдын, тачаангуй, мөн чөтгөрийн адил болж эхэлсэн бөлгөө.

14 Мөн Их Эзэн Бурхан хүмүүнийг газар сайгүй “Ариун Сүнсээр дуудаж мөн тэд наманчлах ёстой хэмээн тэдэнд зарлиглав;

15 Мөн Хүүд “итгэж нүглүүдээсээ наманчилсан болгон нь “аврагдах ёстой; мөн итгэ-

дэггүй мөн наманчлаагүй болгон нь “яллагдах ёстой; мөн үгс нь бат бэх тунхаглалд Бурханы амнаас урагш гарсан бөлгөө; иймийн тул тэдгээр нь гүйцэлдэх ёстой.

16 Мөн Адам мөн түүний эхнэр Ева Бурханыг дуудахаа зогссонгүй. Мөн Адам эхнэр Еватайгаа унтаж, мөн тэрээр жирэмсэлж тэгээд “Каиныг төрүүлж, мөн хэлэв: Би Их Эзэнээс эр хүнтэй боллоо, иймийн тул тэрээр түүний үгсийг эсэргүүцэж болохгүй. Гэвч болгоогтун, Каин анхаарсангүй, хэлсэн нь: Миний мэдэх ёстой тэр Их Эзэн чинь хэн бэ?

17 Мөн тэр дахин жирэмсэлж мөн дүү “Абелыг нь төрүүлэв. Мөн Абел Их Эзэний дуу хоолойг “анхаарав. Мөн Абел хоньчин байв, харин Каин газар боловсруулагч байв.

18 Мөн Каин Сатанд Бурханаас илүү “хайртай байв. Мөн Сатан түүнд тушаан, хэлсэн нь: Их Эзэнд өргөл “өргөгтүн.

19 Мөн цаг хугацааны явцад Каин газрын үр жимснээс Их Эзэнд өргөлөө авчрах нь тохиох болов.

20 Мөн Абел, тэрээр тэрчлэн сүргийнхээ ууган төлүүдээс, мөн тэдгээрийн тарганаас нь авчирдаг байв. Мөн Абелыг,

10в су Баяр баясгалан.

г Иов 19:26;
2 Ниф. 9:4.

11а су Ева.

б 2 Ниф. 2:22–23.

12а Дэд хууль 4:9.

13а су Чөтгөр.

б су Итгэлгүй

байдал.

в Мосе 6:15.

г су Тачаангуй,
Зуурдын; Эгэл хүн.

14а Иохан 14:16–18, 26.

15а су Итгэлтэй байх,
Итгэл.

б су Аврал.

в С ба Г 42:60.

су Ял.

16а Эхл. 4:1–2.

су Каин.

17а су Абел.

б Евр. 11:4.

18а С ба Г 10:20–21.

б С ба Г 132:8–11.

мөн түүний “өргөлийг Их Эзэн хүлээн авав;

21 Харин Каиныг, мөн түүний “өргөлийг тэрбээр хүлээн авсангүй. Эдүгээ Сатан үүнийг мэдэж мөн энэ нь түүнийг баярлуулав. Мөн Каин маш ууртай байв, мөн түүний төрх байдал алдагдав.

22 Мөн Их Эзэн Каинд хэлэв: Яагаад чи ууртай байна вэ? Яагаад төрх байдал чинь алдагдав?

23 Хэрэв чи сайныг хийх аваас, чи “хүлээн авагдах ёстой. Мөн хэрэв чи сайн бишийг хийх аваас, нүгэл хаалган дээр ирж, тэгээд Сатан чамайг эзэмдэхийг хүсэх болно; мөн чи миний зарлигуудыг анхаарахаас бусдаар, би чамайг шилжүүлж өгөх болно, мөн энэ нь чамд түүний хүслийн дагуу байх болно. Мөн чи түүний дээр захирах болно;

24 Учир нь энэ цагаас хойш чи түүний худал хуурмагийн эцэг байх болно; чибээр “Мөхөл хэмээн нэрлэгдэх болно, учир нь чи тэрчлэн дэлхийн өмнө байсан бөлгөө.

25 Мөн ирэх цагт энэ нь хэлэгдэх болно — Эдгээр “жигшүүрт хэргүүд Каинаас ирсэн байлаа; учир нь Бурханаас байсан агуу зөвлөгөөг тэрээр эсэргүүцсэн юм; мөн энэ нь, чамайг үл наманчилбал чиний дээр миний тавих зүхэл болно.

26 Мөн Каин ууртай байв, мөн цаашид Их Эзэний дуу хоолой ч, мөн Их Эзэний өмнө цэвэр ариун байдалд алхаж асан, дүү Абелыгаа ч сонссонгүй.

27 Мөн Каин хийгээд түүний ах нарын улмаас Адам бас түүний эхнэр Их Эзэний өмнө гашуудав.

28 Мөнхүү улиран тохиох дор Каин ах нарынхаа охидын нэгийг эхнэр болгон авч, мөн тэд Сатанд Бурханаас илүү “хайртай болов.

29 Мөн Сатан Каинд хэлэв: Мөн хэрэв чи үүнийг ярих аваас чи үхэх болно хэмээн хоолойгоороо надад тангарагла; мөн тэд үүнийг ярихгүй гэдгийг ах нараараа толгойгоор нь мөн амьд Бурханаар тангараглуул; учир нь хэрэв тэд үүнийг ярих аваас, тэд гарцаагүй үхэх болно; мөн үүнийг эцэг чинь мэдэж болохгүй; мөн энэ өдөр дүү Абелыг чинь би чиний гарт шилжүүлэх болно.

30 Мөн тэрээр түүний зарлигуудын дагуу үйлдэх болно гэдгийг Сатан тангараглав. Мөн эдгээр бүх зүйлүүд нууцаар хийгдсэн байлаа.

31 Мөн Каин хэлэв: Би “аллага хийж мөн ашиг олж болох энэ агуу нууцын эзэн Махан үнэхээр би мөн. Иймийн тул Каин Эзэн “Махан хэмээн нэрлэгддэг байв,

20a су Өргөл;
Золиослол.

21a Эхл. 4:3–7.

23a Эхл. 4:7;

С ба Г 52:15; 97:8.

24a су Мөхлийн

хүүхдүүд.

25a Хил. 6:26–28.

28a Мосе 5:13.

31a су Аллага.

б ө.х. “Оюун”

“устгагч” “агуу

нэгэн” эдгээр нь “Махан” гэсэн үгийн үндэстэй адил утгатай байж болно.

мөн тэрээр өөрийн ёс буст алдаршив.

32 Мөн Каин талбайд очиж, тэгээд Каин дүү Абелтайгаа ярилцав. Мөнхүү улиран тохиох дор тэднийг талбайд байхад, Каин дүү Абелынхаа эсрэг босч, мөн түүнийг алав.

33 Мөн Каин өөрийн хийснээрээ “бахархан хэлэв: Би чөлөөтэй байна; дүүгийн минь мал сүрэг гарцаагүй миний гарт орлоо.

34 Мөн Их Эзэн Каинд хэлэв: Дүү Абел чинь хаана байна? Мөн тэр хэлсэн нь: Би мэдэхгүй. Би дүүгийнхээ “манаач юм уу?

35 Мөн Их Эзэн хэлэв: Чи юу хийчих вэ? Дүүгийн чинь цусны дуу хоолой газраас надад хашгирч байна.

36 Мөн эдүгээ дүүгийн чинь цусыг чиний гараас хүлээн авахаар амаа ангайсан дэлхийгээр чи зүхэгдэх болно.

37 Чамайг газар боловсруулахад үүнээс хойш энэ нь хүч чадлаараа чамд өгөхгүй байх болно. Чи дэлхийд “зугтагч мөн хэрэн тэнүүчлэгч байх болно.

38 Мөн Каин Их Эзэнд хэлэв: Дүүгийн минь мал сүргийн улмаас Сатан намайг “уруу татсан бөлгөө. Мөн би ч бас ууртай байв; учир нь та минийхийг биш, харин түүний

өргөлийг хүлээн авсан билээ; шийтгэл минь миний тэвчиж чадахаас илүү их бөлгөө.

39 Болгоогтун та энэ өдөр намайг Их Эзэний нүүрнээс хөөн зайлууллаа, мөн бибээр таны нүүрнээс нуугдах болно; мөн би дэлхийд зугтагч хийгээд хэрэн тэнүүчлэгч байх болно; мөнхүү улиран тохиох дор намайг олох тэрээр алдсуудын минь учир намайг алах болно, учир нь эдгээр зүйлүүд Их Эзэнээс нуугдах нь үгүй бөлгөө.

40 Мөн Их Эзэн бибээр түүнд хэлэв: Хэн ч чамайг аллаа гэсэн, өс хонзон нь түүн дээр долоо дахин байх болно. Мөн түүнийг олсон хэн ч гэсэн түүнийг алахгүйн тулд Их Эзэн бибээр Каин дээр “тэмдэг тавьсан болой.

41 Мөн Каин Их Эзэний “оршихуйгаас таслагдсан байв, мөн өөрийн эхнэр бас дүү нарынхаа олонтой нь Еденийн зүүн талд, Нодын нутагт оршин сууж байв.

42 Мөн Каин эхнэртэйгээ унтаж, мөн тэрээр жирэмсэлж мөн Енохыг төрүүлэв, мөн тэрээр тэрчлэн олон хөвгүүд мөн охидыг төрүүлэв. Мөн тэрээр хот барьж, мөн тэрээр уг “хотын нэрийг өөрийн хүү Енохын нэрээр нэрлэв.

33a су Бардамнал;

Дэлхийнх.

34a Эхл. 4:9.

37a Эхл. 4:11–12.

38a су Шунах; Уруу татах, Уруу таталт.

40a Эхл. 4:15.

41a Моисе 6:49.

42a ө.х. Каины удамд

Енох нэртэй хүн байсан бөгөөд түүний хүмүүсийн дунд ийм нэртэй хот байжээ. Үүнийг зөв шударга Сетийн удмын

Енох буюу түүний хот Сион тэрчлэн Енохын хот хэмээн нэрлэгддэг байсантай бүү андуураарай.

43 Мөн Ирад, бас бусад хөвгүүд хийгээд охид Еноход төрөв. Мөн Ирад Мехуиаелыг, мөн бусад хөвгүүд хийгээд охидыг төрүүлэв. Мөн Мехуиаел Метушаелыг, мөн бусад хөвгүүд хийгээд охидыг төрүүлэв. Мөн Метушаел Ламехыг төрүүлэв.

44 Мөн Ламех өөртөө хоёр эхнэр авав; нэгнийх нь нэр Ада, мөн нөгөөгийнх нь нэр Зилла байв.

45 Мөн Ада Иабалыг төрүүлэв; тэрээр майханд амьдрагчдын эцэг байлаа, мөн тэд мал адгуулагчид байв; мөн ахынх нь нэр, ятга болон бадралт баг бишгүүр мэтийг тоглогч тэд бүгдийн эцэг асан Иубал байв.

46 Мөн Зилла, тэрээр зэс хийгээд төмрийн урлалд мэргэшигч бүрийн зааварлагч Тубал Каиныг тэрчлэн төрүүлэв. Мөн Тубал Каины эгчийг Наама гэдэг байв.

47 Мөн Ламех өөрийн эхнэрүүд, Ада Зилла хоёрт хэлэв: Ламехын эхнэрүүд та нар, миний дуу хоолойг сонсоцгоо, миний яриаг анхаар; учир нь намайг шархдуулсны төлөө, мөн намайг гомдоосон учир бибээр нэг хүнийг, залуу хүнийг алсан билээ.

48 Хэрэв Каинаас долоо дахин өс хонзон авах ёстой болбоос, Ламех “далан долоо дахин байх нь зөв байв;

49 Учир нь Ламех, Каины маягаар Сатантай “гэрээнд орж, үүндээ тэрээр Эзэн Махан, Сатанаар Каинд гүйцэлдсэн тэрхүү агуу нууцын эзэн болсон бөлгөө; мөн Енохын хүү Ирад, тэдний нууцыг мэдээд, үүнийг Адамын хөвгүүдэд илчилж эхэлсэн ажээ;

50 Иймийн тул Ламех уурласны улмаас түүнийг алав, Каинтай адил өөрийн дүү Абелыг ашиг олохын төлөө бус, харин тэрээр түүнийг тангаргийн улмаас хөнөөв.

51 Учир нь, Каины өдрүүдээс “нууц хуйвалдаан байв, мөн тэдний ажлууд харанхуйд байлаа, мөн хүн болгон түүний ах дүүс гэдгийг мэддэг байв.

52 Иймийн тул Их Эзэн Ламехыг, мөн түүний гэр орныг, мөн Сатантай гэрээнд орсон тэд бүгдийг зүхэв; учир нь тэд Бурханы зарлигуудыг сахиагүй аж, мөн энэ нь Бурханы таалалд эс нийцэв, мөн тэрбээр тэдэнд тохинуулсангүй, мөн тэдний ажлууд жигшүүртэй байв, мөн хүмүүний бүх “хөвгүүдийн дунд дэлгэрч эхлэв. Мөн энэ нь хүмүүний хөвгүүдийн дунд байв.

53 Мөн хүмүүний охидын дунд эдгээр зүйлүүд яригдсан байсангүй, учир нь Ламех уг нууцыг өөрийн эхнэрүүдэд

48а Эхл. 4:24.
ө.х. Каинд Тэрээр үйлдсэнээс илүү ихийг Сатан түүний төлөө

үйлдэх болно хэмээн Ламех сагсуурч байв. Түүний бодлын шалтгааныг шүлэг

49, 50-д дүрсэлжээ.
49а су Тангараг.
51а су Нууц хуйвалдаанууд.
52а Моисе 8:14–15.

ярьсан байжээ, мөн тэд түүний эсрэг босч, мөн эдгээр зүйлүүдийг гадагш нь зарлан мэдэгдэж, мөн өрөвч сэтгэл байсангүй;

54 Иймийн тул, Ламех жигшигдэж, мөн зайлуулагдаж, мөн тэрээр үхэхгүйн тулд хүмүүний хөвгүүдийн дунд ирсэнгүй.

55 Мөн ийн “харанхуйн ажлууд хүмүүний бүх хөвгүүдийн дунд ноёрхож эхлэв.

56 Мөн Бурхан дэлхийг гашуун зүхлээр зүхэв, мөн ёс бусчуудад, өөрийнхөө бий болгосон хүмүүний бүх хөвгүүдэд ууртай байлаа;

57 Учир нь тэд түүний дуу хоолойг анхаарсангүй, мөн түүний “Төрсөн Ганц Хүүд, бүр цагийн голчид ирэх болно хэмээн түүний тунхагласан, дэлхийн суурины өмнөөс бэлтгэгдсэн түүнд итгэсэнгүй.

58 Мөн ийн Бурханы оршихуйгаас урагш илгээгдсэн ариун “тэнгэр элчүүдээр мөн түүний Ариун Сүнсний “бэлгээр тунхаглагдсан “Сайн мэдээ эхлэлээс номлогдож эхлэв.

59 Мөн ийн бүх зүйл ариун ёслолоор Адамд батлагдсан байлаа, мөн сайн мэдээ номлогдож, мөн энэ нь дэлхийд, үүний төгсгөл хүртэл байх ёстой тогтоол урагш илгээгдсэн буюу. Амен.

БҮЛЭГ 6

(1830 оны арваннэгдүгээр сараас—арванхоёрдугаар сар)

Адамын үр удам дурсамжийн ном хадгалав—Түүний зөв шударга үр удам наманчлалыг тунхагладаг—Бурхан Еноход өөрийгөө илчлэв—Енох сайн мэдээг номлов—Авралын төлөвлөгөө Адамд илчлэгдэв—Тэрбээр баптисм болон санваар хүлээж авав.

Мөн “Адам Бурханы дуу хоолойг анхаарав, мөн өөрийн хөвгүүдийг наманчлахад дуудав.

2 Мөн Адам эхнэртэйгээ дахин унтав, мөн тэрээр хүү төрүүлэв, мөн тэрбээр түүний нэрийг “Сет гэв. Мөн Адам Бурханы нэрийг алдаршуулав, учир нь тэрбээр хэлсэн нь: Каины алсан Абелин оронд Бурхан өөр нэг үрийг надад заяав.

3 Мөн Бурхан өөрийгөө Сетэд илчлэв, мөн тэрээр эсэргүүцэн боссонгүй, харин ах Абелинхаа адилаар хүлээн авч болохуйц “өргөл өргөв. Мөн түүнд бас нэг хүү төрөв, мөн тэрбээр түүний нэрийг Енош хэмээв.

4 Мөн тэгээд эдгээр эрчүүд Их Эзэний нэрийг “дуудаж эхлэв, мөн Их Эзэн тэднийг адисалсан болой;

5 Мөн Адамын хэл дээр

55a су Сүнсний харанхуй; Ёс бус, Ёс бус байдал.

57a су Есүс Христ.

58a Алма 12:28–30;

Моро. 7:25, 29–31.

су Тэнгэр элчүүд.

б су Ариун Сүнсний

бэлэг.

в су Сайн мэдээ.

6 1a су Адам.

2a Эхл. 4:25. су Сет.

3a су Золиослол.

4a Эхл. 4:26.

су Залбирал.

цэдэглэгдсэн дурсамжийн “ном хөтлөгдөж байв, учир нь ^ббурханлиг нөлөөний сүнсээр бичихийн тулд Бурханыг дуудсан болгонд энэ нь өгөгдсөн байлаа;

6 Мөн тэдний хүүхдүүд цэвэр бөгөөд бохирлогдоогүй хэлтэй байж, унших хийгээд бичихийг тэднээр заалгадаг байв.

7 Эхлэлд байсан мөн тэрхүү “Санваар эдүгээ дэлхийн төгсгөлд тэрчлэн байх болно;

8 Эдүгээ тэрбээр “Ариун Сүнсээр урагш хөдөлгөгдөн, Адам энэхүү бошиглолыг ярив, мөн Бурханы ^бхүүхдүүдийн ^вудмын бичиг хөтлөгдсөн байв. Мөн Бурхан хүнийг бүтээсэн тэр өдөр Бурхантай адилаар түүнийг тэрээр бий болгосон байв хэмээн энэ нь Адамын удмын бичгийн ‘номонд байв.

9 Тэрээр өөрийн биеийн “дүр төрхөөр ^бтэднийг, эрэгтэй мөн эмэгтэйг бүтээж, мөн тэднийг адислан, мөн тэд бүтээгдэж, мөн Бурханы ^бхөлийн гишгүүр дээрх нутагт амьд ^вбодгалиуд болсон тэр өдөр тэдний ^днэрийг Адам хэмээн дуудсан бөлгөө.

10 Мөн “Адам нэг зуун гучин жил амьдраад, мөн өөрийнхөө адил, өөрийн ^бдүр

төрх бүхий хөвгүүнийг төрүүлж, мөн түүний нэрийг Сет хэмээв.

11 Мөн Сетийг төрүүлсний дараа, Адамын өдрүүд найман зуун жил байв, мөн тэрбээр олон хөвгүүд мөн охидыг төрүүлэв;

12 Мөн Адамын амьдарсан бүх өдрүүд найман зуун гучин жил байв, мөн тэрбээр нас нөгчив.

13 Сет нэг зуун таван жил амьдрал, мөн Еношийг төрүүлэв, мөн өөрийн бүх өдрүүдэд бошиглож, мөн хүү Еноштоо Бурханы замуудаар заадаг байлаа; иймийн тул Енош тэрчлэн бошиглодог байв.

14 Мөн Сет, тэрээр Еношийг төрүүлсний дараа найман зуун долоон жил амьдарч, мөн олон хөвгүүд хийгээд охидыг төрүүлэв.

15 Мөн газрын бүх гадаргуу дээр хүмүүний үрс үй олон байв. Мөн тэдгээр өдрүүдэд хүмүүний дунд Сатан агуу “ээгнэлтэй байв, мөн тэдний зүрх сэтгэлд хэрцгийгээр эзэрхэж байв; мөн тэр цагаас хойш дайнууд хийгээд цус урсгалтууд ирэв; мөн хүний гар хүчийг эрэлхийлэн, ^бнууц ажлуудын улмаас үхлийг гүйцэтгэхэд ах дүүсийнхээ эсрэг байв.

5a Абр. 1:28, 31.
су Дурсамжийн ном.

б су Сүнсний удирдамж, Сүнслэгээр нөлөөлөгдөх.

7a су Санваар.
8a 2 Петр 1:21.

б су Удмын бичиг.

в су Бурханы хөвгүүд охид.

г Эхл. 5:1.

9a Эхл. 1:26–28;
Мосе 2:26–29;
Абр. 4:26–31.

б су Хүмүүн, Хүмүүс.
в Абр. 2:7.

г су Бие.

д Мосе 1:34; 4:26.

10a С ба Г 107:41–56.

б Эхл. 5:3;

С ба Г 107:42–43;
138:40.

15a Мосе 5:13.

б су Нууц хуйвалдаанууд.

16 Сетийн бүх өдрүүд найман зуун арван хоёр жил байв, мөн тэрбээр нас нөгчив.

17 Мөн Енош ерэн жил амьдарч, мөн “Кенаныг төрүүлэв. Мөн Енош мөн Бурханы хүмүүсийн үлдсэн нь Шулон хэмээн нэрлэгддэг байсан газраас гарч яван, мөн тэрбээр Кенан хэмээн хүүгийнхээ нэрээр нэрлэсэн амлалтын нутагт оршин сууж байв.

18 Мөн Енош, тэрээр Кенаныг төрүүлсний дараа найман зуун арвантаван жил амьдрал, мөн олон хөвгүүд хийгээд охидыг төрүүлэв. Мөн Еношийн бүх өдрүүд есөн зуун таван жил байлаа, мөн тэрбээр нас нөгчив.

19 Мөн Кенан далан жил амьдарч, мөн Махалалеелыг төрүүлэв; мөн Кенан Махалалеелыг төрүүлсний дараа найман зуун дөчин жил амьдрал, мөн хөвгүүд хийгээд охидыг төрүүлэв. Мөн Кенаны бүх өдрүүд есөн зуун арван жил байв, мөн тэрбээр нас нөгчив.

20 Мөн Махалалеел жаран таван жил амьдарч, мөн Иаредыг төрүүлэв; Махалалеел, тэрбээр Иаредыг төрүүлсний дараа найман зуун гучин жил амьдрал, мөн хөвгүүд хийгээд охидыг төрүүлэв. Мөн Махалалеелын бүх өдрүүд найман зуун ерэн-таван жил байв, мөн тэрээр нас нөгчив.

21 Мөн Иаред нэг зуун жаран хоёр жил амьдарч, мөн “Енохыг төрүүлэв; мөн тэрээр Енохыг төрүүлсний дараа Иаред найман зуун жил амьдрал, мөн хөвгүүд хийгээд охидыг төрүүлэв. Мөн Иаред Бурханы бүх замуудаар Еноход заадаг байв.

22 Мөн энэ нь Бурхан өөрөө түүнтэй ярьсан, Бурханы “хүү асан Адамын хөвгүүдийн удмын бичиг болой.

23 Мөн тэд зөв шударга ёсны “номлогчид байв, мөн ярьж мөн ^ббошиглож байв, мөн бүх хүмүүнийг, хаа сайгүй, ^{на}манчлахад дууддаг байлаа; мөн ^{итгэл} нь хүмүүний үрст заагддаг байв.

24 Мөнхүү улиран тохиох дор Иаредын бүх өдрүүд есөн зуун жаран хоёр жил байв, мөн тэрбээр нас нөгчив.

25 Мөн Енох жарантаван жил амьдарч, мөн “Метуселаг төрүүлэв.

26 Мөнхүү улиран тохиох дор Енох газар нутагт, хүмүүсийн дунд аялав; мөн түүнийг аялж явахад, тэнгэрээс Бурханы Сүнс буун ирж, мөн түүн дээр оршин байв.

27 Мөн тэрээр: Енох, хүү минь, энэ хүмүүст бошиглогтун, мөн — Наманчлагтун хэмээн тэдэнд хэл гэж өгүүлэх дуу хоолойг тэрээр тэнгэрээс сонсов, учир нь ийн Их Эзэн хэлж байв: Би энэ хүмүүст

17a Эхл. 5:10–14;
С ба Г 107:45, 53.
21a Эхл. 5:18–24;
Мосе 7:69; 8:1–2.
су Енох.

22a Лук 3:38.
23a су Бошиглогч.
б су Бошиглох,
Бошиглол.
в су Наманчлах,

Наманчлал.
г су Итгэл.
25a су Метусела.

“ууртай байна, мөн миний догшин уур тэдний эсрэг дүрэлзэж байна; учир нь тэдний зүрх сэтгэл хатуурч, мөн тэдний чих сонсоход ^бдүйрэнгэ байна, мөн тэдний нүд холыг харж ^ачадахгүй байна;

28 Мөн эдгээр олон үеийнхний тулд, би тэднийг бүтээсэн тэр өдрөөс хойш, тэд замаасаа “гажиж, мөн намайг үгүйсгэсэн билээ, мөн харанхуйд тэд өөрсдийн зөвлөгөөг эрэлхийлсэн буюу, мөн жигшүүрт хэргүүддээ тэд аллагыг төлөвлөдөг байв, мөн тэдний эцэг Адамд миний өгсөн зарлигуудыг сахьсан нь үгүй.

29 Иймийн тул, тэд хуурамчаар тангарагласан байна, мөн тэд “тангаргаараа үхлийг өөрсдийнхөө дээр авчрав; мөн хэрэв тэд эс наманчлах аваас, тэдний тулд ^бтамыг би бэлтгэсэн билээ;

30 Мөн энэ бол дэлхийн эхлэлд, үүний сууринаас өөрийн амнаас мөн та нарын эцгүүд, миний үйлчлэгчдийн амаар миний урагш авчирсан тогтоол бөлгөө, бүр энэ нь дэлхийд, үүний хязгааруудад илгээгдэхийн тул би үүнийг тунхагласан юм.

31 Мөн Енох эдгээр үгсийг сонсоод тэрээр Их Эзэний өмнө газар уруу доош мэхийж, мөн Их Эзэний өмнө

ярьж, хэлэв: Бибээр таны мэлмийд тааллыг олсны учир юу билээ, гэтэл мөн би залуу, мөн бүх хүмүүс намайг үзэн яддаг буюу; учир нь би ярихдаа “удаан бөлгөө; иймийн тул бибээр таны үйлчлэгч мөн үү?

32 Мөн Их Эзэн Еноход хэлэв: Урагш одож мөн чамд миний зарлигласанчлан үйлдэгтүн, мөн хүмүүн чамайг цоо хатгах нь үгүй. “Амаа нээ, мөн энэ нь дүүргэгдэх болно, мөн би чамд үгийг өгөх болно, учир нь бүх махан бодь миний гарт байдаг, мөн надад сайн санагдсанаар бибээр үйлдэх болно.

33 Энэ хүмүүст хэлэгтүн: Өөрсдийг тань бий болгосон Их Эзэн Бурханд үйлчлэхийн тулд энэ өдөрт “сонгоцгоо та нар.

34 Болгоогтун миний Сүнс чам дээр байна, иймийн тул, чиний бүх үгсийг бибээр зөвтгөх болно; мөн “уулс чиний өмнө зугтах болно, мөн ^бгол мөрнүүд голдрилоосоо эргэх болно; мөн чибээр надад, мөн би чамд орших болно. Тиймийн тул надтай хамт ^аалхагтун.

35 Мөн Их Эзэн Еноход хандан ярьж, мөн түүнд хэлэв: Нүдэндээ шавар түрхээд мөн үүнийг угаа, мөн чи харах болно. Мөн тэрээр үүнчлэн хийв.

27а С ба Г 63:32.

б Мат. 13:15;

2 Ниф. 9:31;

Мозай 26:28;

С ба Г 1:2, 11, 14.

в Алма 10:25; 14:6.

28а су Эсэргүүцэл.

29а су Тангараг.

б су Там.

31а Ег. 4:10–16;

Иер. 1:6–9.

32а С ба Г 24:5–6; 60:2.

33а су Сонгох эрх.

34а Мат. 17:20.

б Моисе 7:13.

в Эхл. 5:24; Моисе 7:69.

су Аллах, Бурхантай хамт алхах.

36 Мөн Бурханы бүтээсэн “сүнснүүдийг тэрээр болгоов; мөн ^бердийн нүдэнд үл харагдах зүйлүүдийг тэрээр тэрчлэн болгоов; мөн түүнээс хойш уг нутагт нэг үг тараагдсан нь: Их Эзэн энэ хүмүүст нэг “үзмэрчийг бэлтгэжээ гэсэн нь байв.

37 Мөнхүү улиран тохиох дор Енох уг нутагт хүмүүсийн дунд урагш одож, толгод дээр хийгээд өндөр газруудад зогсон, тэдний ажлуудын эсрэг гэрчилж, мөн чанга дуу хоолойгоор хашгирч байв; түүнээс болж бүх хүмүүн “гомдсон байлаа.

38 Мөн майханд оршин суугчдад хандан: Үзмэрчийг харахаар биднийг тийшээ явах хооронд та нар эндээ үлдэж майхнуудаа харж бай, учир нь тэрээр бошиглодог, мөн уг нутагт тэнд нэг хачин зүйл буй; нэгэн зэрлэг хүн бидний дунд орж ирлээ хэмээн өндөр газруудад хэлэх түүнийг сонсохоор тэд урагш ирцгээв.

39 Мөнхүү улиран тохиох дор тэд түүнийг сонсоод нэг ч хүн түүнд гар хүрсэнгүй; учир нь түүнийг сонссон тэд бүгд дээр айдас иржээ; учир нь тэрээр Бурхантай хамт алхаж байв.

40 Мөн нэр нь Махижа гэдэг байсан нэг хүн түүн дээр ирж түүнд хэлсэн нь: Та хэн бэ, мөн та хаанаас ирснээ бидэнд тодорхой хэлээч?

41 Мөн тэрбээр тэдэнд хэлэв: Миний эцгүүдийн нутаг, энэ өдрийн хувьд зөв шударга ёсны нутаг, Кенаны нутгаас гарч ирсэн болой би. Мөн эцэг минь надад Бурханы бүх замуудаар заадаг байлаа.

42 Мөнхүү улиран тохиох дор далайн зүүнтэйгээр Кенаны нутгаас аялж явахдаа бибээр нэг үзэгдлийг болгоов; мөн харагтун, би тэнгэрийг үзэж, мөн Их Эзэн надтай ярилаа, мөн надад зарлиг өгөв; иймийн тул, энэ шалтгааны учир уг зарлигийг сахихын тулд би эдгээр үгсийг урагш ярих ажгуу.

43 Мөн Енох үгээ үргэлжлүүлэн, хэлэв: Надтай ярьсан Их Эзэн мөн тэнгэрийн Бурхан болой, мөн тэрбээр миний Бурхан бас та нарын Бурхан билээ, мөн та нар миний ахан дүүс билээ, мөн юуны учир та нар өөрсдөө “зөвлөж, мөн тэнгэрийн Бурханыг үгүйсгэнэ вэ?

44 Тэнгэрийг тэрээр хийсэн билээ; мөн “дэлхий түүний “хөлийн гишгүүр; мөн үүний суурь нь түүнийх. Болгоогтун, тэрээр үүнийг тавьсан юм, мөн үүний гадаргуу дээр тэрээр үй олон хүмүүнийг авчирсан болой.

45 Мөн үхэл бидний эцгүүд дээр ирэв; гэсэн хэдий ч бид тэднийг мэдэх бөлгөө, мөн үгүйсгэж үл чадна, мөн бүр бүхнээс эхнийхийг, бүр Адамыг бид мэднэ.

36a су Сүнсний бүтээл.
б Моисе 1:11.
в су Үзмэрч.

37a 1 Ниф. 16:1–3.
43a Сур. үгс 1:24–33;
С ба Г 56:14–15.

44a Дэд хууль 10:14.
б Абр. 2:7.

46 Учир нь Бурханы хуруугаар өгөгдсөн загварын дагуу бид өөрсдийнхөө дунд “дурсамжийн номыг бичсэн билээ; мөн энэ нь бидний төрөлх хэл дээр өгөгдсөн бөлгөө.

47 Мөн Енох Бурханы үгсийг урагш ярьж байхад, хүмүүс дагжин чичирч, мөн түүний дэргэд зогсож чадахгүй байв.

48 Мөн тэрбээр тэдэнд хэлэв: Адам “унасны улмаас бид байгаа ажгуу; мөн түүний уналтаар ^бүхэл ирсэн юм; мөн бид зовлон хийгээд гаслан хүртэгчид болгогдсон билээ.

49 Сатан хүмүүний үрсийн дунд ирснийг, мөн тэр өөрийгөө шүтүүлэхээр тэднийг “уруу татдагийг болгоогтун; мөн хүмүүн ^бзуурдын, ^атачаангуй, чөтгөр мэт болж, мөн Бурханы оршихуйгаас ^втаслагдсан бөлгөө.

50 Гэвч бүх хүмүүн наманчлах ёстойг Бурхан бидний эцгүүдэд мэдүүлсэн билээ.

51 Мөн тэрбээр бидний эцэг Адамыг өөрийн дуу хоолойгоор дуудаж, хэлсэн нь: Бибээр Бурхан билээ; би дэлхийг, мөн тэднийг махан

бодид байхаас “өмнө ^бхүмүүнийг бий болгосон бөлгөө.

52 Мөн тэрбээр тэрчлэн түүнд хэлэв: Хэрэв чи над уруу эргэж, мөн миний дуу хоолойг анхаарч, мөн өөрийн бүх зөрчлөөс наманчлан, мөн бүр усан дотор “ач ивээл хийгээд үнэнээр дүүрч миний Төрсөн Ганц Хүү болох ^бЕсүс Христийн, тэнгэрийн дор өгөгдөх ёстой цорын ганц үүгээр “аврал хүмүүний үрст ирэх ёстой тэрхүү ^внэрээр ^абаптисм хүртэх аваас, бүх зүйлийг түүний нэрэнд асууж, та нар Ариун Сүнсний хүлээж авах болно, мөн та нар юуг ч асуулаа гэсэн, энэ нь та нарт өгөгдөх болно.

53 Мөн бидний эцэг Адам Их Эзэнд хандан ярьж мөн хэлэв: Хүмүүн наманчилж мөн усанд баптисм хүртэхийн учир юу билээ? Мөн Их Эзэн Адамд хэлсэн нь: Болгоогтун Еденийн Цэцэрлэгт чиний зөрчлийг би чамд “өршөөсөн билээ.

54 Эцэг эхийн нүглүүд “хүүхдүүдийнх нь толгой дээр байж үл болох анхны гэмийг Бурханы ^бХүү “цагаатгасан билээ, учир нь тэд дэлхийн сууринаас цэвэр болой хэ-

46a су Дурсамжийн ном.

48a 2 Ниф. 2:25.

су Адам, Ева хоёрын уналт.

б су Биений үхэл.

49a Моисе 1:12.

су Уруу татах, Уруу таталт.

б Мозая 16:3–4;

Моисе 5:13.

су Тачаангуй,

Зуурдын.

в су Тачаангуй, Тачаангуй байдал.

г су Сүнсний үхэл.

51a су Сүнсний бүтээл.

б су Хүмүүн,

Хүмүүс—Хүн,

Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүд.

52a су Ач ивээл.

б су Есүс Христ.

в су Аврал.

г Уйлс 4:12;

2 Ниф. 31:21.

д 3 Ниф. 11:23–26.

су Баптисм, Баптисм хүртээх.

53a су Уучлах.

54a Мозая 3:16.

б су Есүс Христ.

в су Цагаатгах,

Цагаатгал.

мээх үг хүмүүсийн дунд эндээс тархсан байлаа.

55 Мөн Их Эзэн Адамд ярьж, хэлсэн нь: Чиний хүүхдүүд нүгэлд төрөхийн хэрээр, бүр тэд өсч эхлэхэд, “нүгэл тэдний зүрх сэтгэлд боловсорч, мөн тэд сайн сайхны үнэ цэнийг мэдэж болохын тулд тэд ^бгашууныг амсаж болно.

56 Мөн муугаас сайныг ялгаж мэдэх нь тэдэнд өгөгдсөн болой, иймийн тулд тэд өөрсдөдөө “чөлөөтэйгөөр сонгогч, мөн би чамд өөр хууль болон зарлиг өгсөн билээ.

57 Иймийн тул хүмүүн хаа сайгүй “наманчлах ёстой, үүнийг хүүхдүүддээ заагтун, эс бөгөөс тэд Бурханы Хаант улсыг өвлөж чадах нь үгүй, учир нь ^бцэвэр ариун бус зүйл тэнд оршиж чадах нь үгүй, эсвээс түүний дэргэд ^борших нь үгүй; учир нь Адамын хэлээр ^аАриун Хүн гэдэг нь түүний нэр болой, мөн түүний Төрсөн Ганцын нэр нь ^аХүний Хүү, бүр Есүс Христ цагийн голчид ирэх шударга ^аШүүгч бөлгөө.

58 Тиймийн тул, эдгээр зүйлүүдийг “хүүхдүүддээ чөлөө-

тэйгөөр заах зарлигийг би чамд өгч байна, хэлэх нь:

59 Зөрчлийн шалтгаанаар уналт ирдэг, тэрхүү уналт үхлийг авчирдаг бөгөөд мөн та нар усаар мөн цусаар мөн миний хийсэн “сүнсээр дэлхийд төрөхийн хэрээр мөн ийн ^бтоосноос амьд бодгаль болон, бүр ийн та нар цэвэршигдэж тэнгэрийн хаант улсад ^бусаар мөн Сүнсээр дахин ^атөрж мөн цусаар бүр миний Төрсөн Ганцын цусаар бүх нүглээс ариусгагдах ёстой, мөн энэ дэлхийд мөнх амьдралын ^бүгсийг мөн ирэх дэлхийд бүр үхэшгүй байдлын ^балдар сууд мөнх амьдралыг та нар ^бэдэлж болно;

60 Учир нь “усаар уг зарлигийг сахьдаг болой та нар; Сүнсээр ^бзөвтгөгддөг болой та нар, мөн ^бцусаар ^аариусгагддаг болой та нар;

61 Тиймийн тул чамд орших нь өгөгдсөн бөлгөө; тэнгэрийн цэдэг; “Тайтгаруулагч; үхэшгүй алдар суугийн амар амгалангийн зүйлүүд; бүх зүйлд амьдралыг өгдөг, бүх зүйлийг амьдруулдаг тэр зүйл; бүх зүйлийг мэддэг мөн мэргэн

55a су Нүгэл.

б С ба Г 29:39.
су Дайсан.

56a 2 Ниф. 2:26–27;
Хил. 14:29–30.

су Сонгох эрх.

57a 1 Кор. 6:9–10.
су Наманчлах,
Наманчлал.

б 1 Ниф. 10:21.
су Цэвэр болон

Цэвэр бус байдал.

в Дуул. 24:3–4;
1 Ниф. 15:33–36;

Морм. 7:7;

С ба Г 76:50–62.

г Моcе 7:35.

су Ариун Хүн.

д су Хүний Хүү.

е су Есүс Христ—

Шүүгч; Шударга
байдал.

58a су Хүүхэд,

Хүүхдүүд.

59a 1 Иохан 5:8.

б Эхл. 2:7; Моcе 4:25;

Абр. 5:7.

в су Баптисм,

Баптисм хүртээх.

г су Дахин төрөх,
Бурханаас төрөх.

д Иохан 6:68.

е су Селестиел

алдар суу.

ё 2 Ниф. 4:15–16;

Алма 32:28.

60a Моро. 8:25.

б су Зөвтгөл,

Зөвтгөх.

в су Цус.

г су Ариусгал.

61a су Ариун Сүнс.

ухаан, нигүүлсэл, үнэн, шударга ёс, мөн шүүлтийн дагуу бүх хүч байдаг тэр зүйл буюу.

62 Мөн эдүгээ, болгоогтун, би чамд хэлж байна: Энэ бол цагийн голчид ирэх миний “Төрсөн Ганцын цусаар дамжин ирэх бүх хүмүүний авралын” төлөвлөгөө юм.

63 Мөн болгоогтун, бүх зүйлд өөрсдийнх нь адил төстнүүд байдаг, мөн бүх зүйл, материаллаг зүйлүүд хийгээд сүнсний зүйлүүд аль аль нь миний тухай “гэрчлэхээр бэлтгэгдэж мөн хийгдсэн болой; дээр тэнгэрт байгаа зүйлүүд, мөн дэлхий дээр байгаа зүйлүүд, мөн дэлхий дотор байгаа зүйлүүд, мөн дэлхийн дор байгаа зүйлүүд, дээрх хийгээд доорх аль аль нь: бүх зүйл миний тухай гэрчилдэг.

64 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн бидний эцэг Адамтай ярьж байх үед Адам Их Эзэнд хандан залбиран гуйж мөн тэрээр Их Эзэний “Сүнсээр алсад аваачигдан, мөн доош ус уруу хийгдэж, усан дор тавигдаж мөн уснаас урагш гаргагдсан ажээ.

65 Мөн ийн тэрбээр баптисм хүртэж, мөн Бурханы Сүнс түүн дээр бууж ирсэн ажгуу, мөн ийн тэрбээр Сүн-

сээр “төрсөн байв, мөн “доторх хүндээ амьдруулагдсан байлаа.

66 Мөн тэрбээр: Галаар, мөн Ариун Сүнсээр “баптисм хүртсэн болой ч хэмээн хэлсэн дуу хоолойг тэнгэрээс сонслоо. Энэ бол үүнээс хойш мөн үүрд Эцэг, мөн Хүүгийн тухай “гэрчлэл юм;

67 Мөн чи бол бүх үүрд мөнхөөс бүх үүрд мөнхөд өдрүүдийн эсвээс жилүүдийн төгсгөлгүй байсан түүний “жягийн дагуу бөлгөө.

68 Болгоогтун, чи надад “нэг, Бурханы хүү билээ; мөн ийн бүгд миний “хөвгүүд болж болно. Амен.

БҮЛЭГ 7

(1830 оны арванхоёрдугаар сар)

Енох зааж, хүмүүсийг удирдан, мөн уулыг хөдөлгөв — Сионы хот үндэслэгдэн байгуулагдав — Енох Хүний Хүүгийн ирэлт, түүний цагаатгагч золиослол, мөн Гэгээнтнүүдийн амилуулалтыг угтан харав — Тэрбээр Сэргээлт, Цугларалт, Хоёрдахь Ирэлт, мөн Сионы эргэн ирэлтийг угтан харав.

Мөнхүү улиран тохиох дор Енох яриагаа үргэлжлүүлэн, хэлэв: Болгоогтун, бидний

62a су Төрсөн Ганц.
б су Гэтэлгэлийн төлөвлөгөө.

63a Алма 30:44;
С ба Г 88:45–47.

64a су Ариун Сүнс.
б су Баптисм,
Баптисм хүртээх.

65a су Дахин төрөх,

Бурханаас төрөх.
б Мозая 27:25;
Алма 5:12–15.

66a С ба Г 19:31.
су Ариун Сүнсний бэлэг.

б 2 Ниф. 31:17–18;
3 Ниф. 28:11.

67a су Мелкизедек

санваар.
68a 1 Иохан 3:1–3;
С ба Г 35:2.

б Иохан 1:12;
С ба Г 34:3.
су Бурханы хөвгүүд охид.

эцэг Адам эдгээр зүйлүүдийг заадаг байв, мөн олон нь итгэж мөн Бурханы “хүүхдүүд болов, мөн олон нь итгэсэнгүй, мөн нүглүүддээ мөхөж, мөн өөрсөд дээр нь юүлэгдэх Бурханы хилэнгийн галт зэвүүцлийн учир тарчлалд, ⁶айж эмээн урагш хүлээж байна.

2 Мөн тэр цагаас хойш Енох бошиглож эхлэн, хүмүүст хэлсэн нь энэ буюу: Би аялж яваад, мөн Махужа газар дээр зогсож мөн Их Эзэнд залбиран гуйсан бөлгөө, тэнгэрээс нэгэн дуу хоолой гарч хэлэв—Эргэгтүн чи, мөн Симеон уулан дээр гарагтун чи.

3 Мөнхүү улиран тохиох дор би эргэж мөн тэрхүү уулан дээр гарав; мөн би уулан дээр зогсож байхдаа тэнгэр нээгдэхийг болгоов, мөн бибээр “алдар суугаар хувцаслагдсан байв;

4 Мөн би Их Эзэнийг харав; мөн тэрбээр миний нүүрний өмнө зогсож байв, мөн тэрбээр бүр нэг хүн нөгөөтэйгөө ярьдгийн адилаар, надтай “нүүр тулан ярьж байлаа; мөн тэрбээр надад хэлэв: ⁶Харагтун, олон үеийн цаг хугацааг хамруулан дэлхийг би чамд үзүүлэх болно.

5 Мөнхүү улиран тохиох дор Шамын хөндийд, мөн харагтун, Шамын хүмүүс болох майханд амьдардаг асан агуу хүмүүсийг бибээр болгоов.

6 Мөн дахин Их Эзэн надад хэлэв: Харагтун, мөн би умард зүг тийш харав, мөн бибээр майханд амьдардаг асан Канааны хүмүүсийг харав.

7 Мөн Их Эзэн надад хэлэв: Бошиглогтун; мөн би бошиглож хэлэв: Канааны үй олон хүмүүс Шамын хүмүүсийн эсрэг тулалдахаар зэхэн урагш одож, бүрмөсөн устгагдсан байхын тулд тэднийг алах болно, мөн Канааны хүмүүс уг нутагт өөрсдийгөө хуваах болно, мөн уг нутаг үржил шимгүй мөн үр жимсгүй байх болно, мөн Канааны хүмүүсээс өөр ямар ч хүмүүс тэнд оршин суух нь үгүйг болгоо;

8 Учрыг болгоогтун, Их Эзэн уг нутгийг их халуунаар зүхэх болно, мөн үүний үржил шимгүй нь үүрдийнх байх болно, мөн тэд бүх хүмүүсийн дунд жигшигдэхийн тулд тэнд “хар нь Канааны бүх хүүхдүүд дээр ирсэн буюу.

9 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн надад хэлэв: Харагтун мөн би харж, тэгээд Шароны нутаг, бас Енохын нутаг, мөн Омнерын нутаг, бас Хинайн нутаг, мөн Шемийн нутаг бас Ханерын нутаг, мөн Хананнайхагийн нутаг, бас эдгээрийн бүх оршин суугчдыг бибээр болгоов;

10 Мөн Их Эзэн надад хэлэв: Энэ хүмүүс уруу очиж, мөн тэдэнд—Би гарч ирэн мөн

7 1а су Бурханы хөвгүүд охид.
б Алма 40:11–14.

3а су зөөгдөлт.
4а Эхл. 32:30;
Дэд хууль 5:4;

Моисе 1:2, 11, 31.
б Моисе 1:4.
8а 2 Ниф. 26:33.

тэднийг зүхлээр арчиж, мөн тэд үхэхгүйн тулд “Наманчлал хэмээн хэлэгтүн.

11 Мөн Эцэг, мөн “ач ивээл хийгээд үнэнээр дүүрэн Хүүгийн нэрээр, мөн Эцэг Хүү хоёрын тухай гэрчилдэг “Ариун Сүнсээр би “баптисм хүртээх ёстой хэмээх зарлигийг тэрээр надад өгөв.

12 Мөнхүү улиран тохиох дор Енох, Канааны хүмүүсээс бусад бүх хүмүүсийг наманчлахад дуудахаа үргэлжлүүлэв;

13 Мөн тэрээр Бурханы хүмүүсийг удирдахын тулд Енохын “итгэл тийм агуу байв, мөн дайснууд нь тэдний эсрэг тулалдахаар ирэв; мөн тэрээр Их Эзэний үгийг ярьж, мөн дэлхий чичрэв, мөн түүний зарлигийн дагуу “уулс зугтав, мөн “гол мөрнүүдийн ус голдрилоосоо эргэв; арслангуудын хүрхрэх нь аглаг буйдаас сонсогдож байв; мөн бүх үндэстнүүд агуу ихээр эмээв, Енохын үг ийм “хүчтэй байв, мөн түүнд Бурханы өгсөн хэлний хүч ийм агуу байлаа.

14 Тэнд тэнгисийн гүнээс газар гарч ирсэн ажээ, мөн тэд зугтаж мөн алс хол зогсон мөн тэнгисийн гүнээс гарч ирсэн газар уруу явахаар Бурханы хүмүүсийн дайснуудын айдас тийм агуу байлаа.

15 Мөн уг нутгийн “аварга хүмүүс, тэрчлэн алсад зогсож байв; мөн Бурханы эсрэг тэмцсэн бүх хүмүүс дээр зүхэл урагш ирэв;

16 Мөн тэр цагаас хойш дайнууд хийгээд цус урсгалт тэдний дунд байв; гэвч Их Эзэн ирж мөн өөрийн хүмүүстэй хамт оршин сууж байв, мөн тэд зөв шударга ёсонд оршин сууж байлаа.

17 Их Эзэнээс эмээх “айдас бүх үндэстнүүд дээр байв, өөрийнх нь хүмүүс дээр байсан Их Эзэний алдар суу тийм агуу байлаа. Мөн Их Эзэн уг нутгийг “адислав, мөн тэд уулсын дээр, мөн өндөр газрууд дээр адислагдсан байлаа, мөн цэцэглэн хөгжив.

18 Мөн Их Эзэн өөрийн хүмүүсийг “Сион хэмээн нэрлэв, учир нь тэд “нэг зүрх сэтгэл мөн нэг оюунтай байлаа, мөн зөв шударга ёсонд оршин сууж байлаа; мөн тэдний дунд ядуус байсангүй.

19 Мөн Енох өөрийн номлолыг Бурханы хүмүүст зөв шударга ёсонд үргэлжлүүлэв. Мөнхүү улиран тохиох дор түүний өдрүүдэд тэрээр Ариун Хот, бүр Сион хэмээн нэрлэгдсэн хот байгуулав.

20 Мөнхүү улиран тохиох дор Енох Их Эзэнтэй ярилцав: мөн тэрбээр Их Эзэнд

10a Моисе 6:57.
су Наманчлах,
Наманчлал.

11a су Ач ивээл.
б су Ариун Сүнс.
в су Баптисм,
Баптисм хүртээх.

13a су Итгэл.
б Мат. 17:20.
в Моисе 6:34.
г су Хүч; Санваартан.
15a Эхл. 6:4; Моисе 8:18.
17a Ег. 23:27.
б Шаст. дээд 28:7–8;

1 Ниф. 17:35.
18a су Сион.
б Үйлс 4:32;
Филип. 2:1–4.
су Эв нэгдэл.

хэлэв: “Сион аюулгүй байдалд үүрд оршин тогтнох нь лавтай. Харин Их Эзэн Еноход хэлэв: Сионыг би адисалсан, харин хүмүүсийн үлдсэнийг нь би зүхсэн бөлгөө.

21 Мөнхүү улиран тохиодор Их Эзэн дэлхийн бүх оршин суугчдыг Еноход үзүүлэв; мөн тэрбээр, цаг хугацааны явцад Сион тэнгэрт дээш “аваачигдахыг болгоож, мөн харав. Мөн Их Эзэн Еноход хэлэв: Миний өргөөг үүрд болгоогтун.

22 Мөн Енох Адамын хүүхдүүд болох хүмүүсийн үлдсэнийг тэрчлэн болгоов, мөн тэд Каины үр удмаас бусад Адамын бүх үр удмын холимог байлаа; учир нь Каины үр удам “хар байв, мөн тэдний дунд байргүй байлаа.

23 Мөн Сион “тэнгэрт дээш аваачигдсаны дараа Енох өөрөөс нь өмнө байсан дэлхийн ^ббүх үндэстнийг “болгоож, мөн харав;

24 Мөн тэнд нэг үеийнхэн нөгөөгийнхөө араас ирж байв; мөн Енох өндөрт байж мөн бүр Эцэгийн, мөн Хүний Хүүгийн цээжинд “өргөгдөн очсон буюу; мөн болгоогтун, Сатаны хүч дэлхийн бүх гадаргуу дээр байв.

25 Мөн тэрээр тэнгэрээс буун ирж буй тэнгэр элчүүдийг харав; мөн тэрбээр:

Дэлхийн оршин суугчид дээр халаг, халаг байг хэмээн хэлэх чанга дуу хоолойг сонсов.

26 Мөн тэрээр Сатаныг болгоов; мөн түүний гарт агуу “гинж байлаа, мөн энэ нь дэлхийн бүхэл гадаргууг ^бхаранхуйгаар бүрхсэн байв; мөн тэрээр дээш харж мөн инээд алдан, мөн түүний “элчүүд баясан байлаа.

27 Мөн Енох тэнгэрээс буун ирж Эцэг, Хүү хоёрын тухай “гэрчилж буй ^бтэнгэр элчүүдийг болгоов; мөн Ариун Сүнс олны дээр байж, мөн тэд тэнгэрийн хүчээр Сионд дээш аваачигдсан байлаа.

28 Мөнхүү улиран тохиодор тэнгэрийн Бурхан хүмүүсийн үлдсэнийг нь харав, мөн тэрээр уйлан хайлав, мөн Енох үүний тухай гэрчлэн хэлэв: Тэнгэр яахан уйлж, мөн уулын дээрх бороо лугаа адил нулимс нь асарна вэ?

29 Мөн Енох Их Эзэнд хэлэв: Та ариун, мөн үүрд мөнхөөс үүрд мөнхөд байдгаа харсаар байж та яахан “уйлж чадна вэ?

30 Дэлхийн маш жижиг хэсгүүдийг, тийм ээ, үүн лугаа адил сая сая “дэлхийг хүн тоолж чадах нь боломжтой байсан сан бол, энэ нь таны ^ббүтээлтүүдийн тоонд эхлэл байхгүй байх сан; мөн таны хөшгүүд өдий хүртэл сунгагдсан байгаа бөлгөө; мөн

20a Моисе 7:62–63.
су Шинэ

Иерусалим.

21a Моисе 7:69.

22a 2 Ниф. 26:33.

23a су Тэнгэр.

б С ба Г 88:47;

Моисе 1:27–29.

в су Үзэгдэл.

24a 2 Кор. 12:1–4.

26a Алма 12:10–11.

б Иса. 60:1–2.

в Иудей 1:6;

С ба Г 29:36–37.

27a су Гэрчлэл.

б су Тэнгэр элчүүд.

29a Иса. 63:7–10.

30a С ба Г 76:24;

Моисе 1:33.

б су Бүтээх, Бүтээл.

та тэнд байсаар буй бөлгөө, мөн таны цээж тэнд буй; мөн тэрчлэн та шударга билээ; та үүрд нигүүлсэнгүй мөн нинжин сэтгэлтэй;

31 Мөн та Сионыг өөрийн бүх бүтээлүүдээс, бүх үүрд мөнхөөс үүрд мөнхөд өөрийн цээжинд аваачсан билээ; мөн өөр юу ч биш харин “амар амгалан, ^бшударга ёс хийгээд “үнэн нь таны хаан сэнтийн мөн чанар бөлгөө; мөн нигүүлсэл таны нүүрний өмнө явах бөгөөд төгсгөл гэж үгүй болой; та яахан уйлж чадна вэ?

32 Их Эзэн Еноход хэлэв: Өөрийн эдгээр ахан дүүсийг болгоогтун; тэд бол миний “гарын бүтээл билээ, мөн би тэднийг бүтээсэн тэр өдөр тэдний ^бмэдлэгийг би тэдэнд өгсөн бөлгөө; мөн би Еденийн Цэцэрлэгт хүнд ^асонгох эрхийг нь өгсөн билээ;

33 Мөн тэд бие биенээ “хайрлах ёстой, мөн өөрсдийн Эцэг намайг сонгох ёстойг би чиний ах дүүст хэлж, мөн тэрчлэн зарлиг өгсөн билээ, гэвч болгоогтун, тэдэнд хайрлах сэтгэл алга, мөн тэд өөрсдийнхөө цусан төрлийнхнийг үзэн яддаг;

34 Мөн миний зэвүүцлийн “гал тэдний эсрэг дүрэлзэж байна; мөн би хурц дургүй-

цэлдээ тэдэн дээр ^бүерүүдийг илгээх болно, учир нь миний догшин хилэн тэдний эсрэг дүрэлзэж байна.

35 Болгоогтун, Би бээр Бурхан; Ариун “Хүн нь миний нэр, Зөвлөгөөний Хүн нь миний нэр; мөн Төгсгөлгүй бөгөөд Мөнх нь тэрчлэн миний ^бнэр.

36 Иймийн тул, бибээр мутраа урагш сунган мөн өөрийн бий болгосон бүх бүтээлүүдийг гартаа барьж чадна; мөн миний “мэлмий тэрчлэн тэдгээрийг цоо ширтэж чадна, мөн миний гарын бүх бүтээлүүд дотор, чиний ах дүүсийн дундах шиг агуу ^бёс бус явдал байсан нь үгүй.

37 Гэвч болгоогтун, тэдний нүглүүд эцгүүдийнх нь толгой дээр байх болно; Сатан тэдний эцэг байх болно, мөн зовлон тэдний муу заяа байх болно; мөн бүхэл тэнгэр тэдний, бүр миний гарын бүх бүтээлүүд дээр уйлах болно; иймийн тул эдгээрийн зовыхыг харсаар байж, тэнгэр уйлах ёсгүй гэж үү?

38 Гэвч болгоогтун, чиний нүд дээр нь байгаа тэд үерүүдэд мөхөх болно; мөн болгоогтун, би тэднийг хорих болно, тэдэнд зориулж би “шорон бэлтгэсэн билээ.

31а су Амар амгалан.

б су Шударга байдал.

в су Үнэн.

32а Моисе 1:4.

б су Мэдлэг.

в су Сонгох эрх.

33а су Хайр.

34а Иса. 30:27;

Нахум 1:6;

С ба Г 35:14.

б Эхл. 7:4, 10;

Моисе 8:17, 24.

су Ноагийн

үеийн үер.

35а Моисе 6:57.

б Моисе 1:3.

36а С ба Г 38:2; 88:41;

Моисе 1:35–37.

б Эхл. 6:5–6;

Моисе 8:22, 28–30.

38а 1 Петр 3:18–20.

су Там.

39 Мөн миний сонгосон “тэр нь миний нүүрний өмнө гуйв. Иймийн тул, тэрээр тэдний нүглүүдийн учир зовсон ажгуу; миний ⁶Сонгосон нь надад эргэж ирэх тэр өдөр тэд наманчлахын хэрээр, мөн тэр өдөр хүртэл тэд “тарчлалд байх болно;

40 Иймийн тул, үүний учир тэнгэр, тийм ээ, мөн миний гарын бүх бүтээл уйлах болно.

41 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Еноход ярьж, мөн хүмүүний үрсийн бүх үйлийн тухай Еноход хүүрнэв; иймийн тул тэдний ёс бус явдал, мөн тэдний зовлонг Енох мэдэж мөн харж, мөн уйлан, мөн гараа урагш сунгасан бөлгөө, мөн түүний “зүрх сэтгэл үүрд мөнхөд мэт үлэмж өсөв; мөн түүний дотор өрөвч сэтгэлээр дүүрэв; мөн бүх үүрд мөнх доргив.

42 Мөн Енох тэрчлэн “Ноа, мөн түүний ⁶гэр бүлийг харав; Ноагийн бүх хөвгүүдийн үр удам цаг зуурын авралаар аврагдах болно;

43 Иймийн тул Ноа “хөвөгч авдар барьсныг Енох харав; мөн Их Эзэн үүнийг хараад инээмсэглэж мөн үүнийг гартаа авав; гэвч ёс бусчуудын үлдсэн дээр нь үер бууж мөн тэднийг залгисан бөлгөө.

44 Мөн Енох үүнийг хараад,

түүний сэтгэл шаналан өвдөв, мөн ахан дүүсийнхээ төлөө уйлж, мөн тэнгэрт хандан хэлэв: Тайвшруулагдахаас “татгалзах болой бибээр; гэвч Их Эзэн Еноход хэлэв: Зүрх сэтгэлээ өргө, мөн баяртай бай мөн хар.

45 Мөнхүү улиран тохиох дор Енох харав: мөн Ноагаас эхлэн тэрээр дэлхийн бүх гэр бүлийг болгоов; мөн тэрээр Их Эзэнд гуйн залбирч хэлэв: Их Эзэний ирэх тэр өдөр хэзээ болох вэ? Гашуудах тэд бүгд “ариусгагдаж мөн мөнх амьдралыг авахын тулд Зөв Шударгын цус хэзээ урсах вэ?

46 Мөн Их Эзэн хэлэв: Энэ нь цагийн “голчид, ёс бус явдал хийгээд өс хонзонгийн өдрүүдэд байх болно.

47 Мөн болгоогтун, Енох Хүний Хүүгийн, бүр махан бодь дахь ирэлтийн өдрийг харав; мөн түүний бодгаль баясан хэлэв: Зөв шударгыг үйлдэгчид өргөгдсөн бөлгөө, мөн “Хурга дэлхийн сууринаас алагдсан буюу; итгэлээр дамжуулан бибээр Эцэгийн цээжинд байна, мөн болгоогтун, ⁶Сион надтай хамт буй.

48 Мөнхүү улиран тохиох дор Енох “дэлхийг харав, мөн үүний дотроос гарах дуу хоолой ийн хэлэхийг нь сонсов:

39a өх Аврагч.

б Моисе 4:2; Абр. 3:27.

сү Есүс Христ.

в сү Ял.

41a Мозая 28:3.

сү Өрөвч сэтгэл.

42a сү Ноа, Библийн

патриарх.

б Моисе 8:12.

43a Эхл. 6:14–16;

Ифер 6:7.

44a Дуул. 77:2;

Ифер 15:3.

45a сү Ариусгал.

46a Моисе 5:57.

47a сү Бурханы Хурга.

б Моисе 7:21.

48a сү Дэлхий—

Дэлхийн

цэвэршилт.

Хүмүүний эх надад халаг, халаг; Хүүхдүүдийнхээ ёс бусын улмаас би өвчиллөө, би ядарч байна. Би хэзээ ^амарч мөн надаас урагш гарах ^ббусармаг явдлаас цэвэршигдэх вэ? Би амарч болохын тулд, миний гадаргуу дээр зөв шударга ёс хэсэг хугацаанд байхын тулд Бүтээгч минь намайг хэзээ цэвэршүүлэх вэ?

49 Мөн дэлхий эмгэнэн гашуудахыг Енох сонсоод, тэрээр уйлж, мөн Их Эзэнд гуйн залбирч, хэлэв: Ай Их Эзэн минь, та дэлхийг үл өрөвдөнө гэж үү? Та Ноагийн хүүхдүүдийг адислахгүй гэж үү?

50 Мөнхүү улиран тохиох дор Енох Их Эзэнд гуйн залбирахаа үргэлжлүүлж, хэлэв: Ай Их Эзэн минь, Ноа болон түүний үр удамд та нигүүлсэлтэй байхын тулд, дэлхий дахиад хэзээ ч үерээр бүрхэгдэхгүй байж болохын тулд Таны Төрсөн Ганцын, бүр Есүс Христийн нэрээр би танаас гуйж байна.

51 Мөн Их Эзэн татгалзаж чадсангүй; тэрбээр Енохтой гэрээнд орж, тэрээр “үерийг болиулах болно, мөн тэрээр Ноагийн хүүхдийг дуудах болно хэмээн түүнд андгайлан тангараг өгөв;

52 Мөн дэлхий оршин тогтнож байх үед түүний үр уд-

мын “үлдэгдэл бүх үндэстнүүдийн дунд ямагт байх болно хэмээх хувиршгүй тогтоолыг тэрээр урагш илгээв;

53 Мөн Их Эзэн хэлэв: Үр удамаар нь дамжин Мессиа, ирэх тэрээр адислагдсан болой; учир нь тэрээр хэлдэг — Би бол “Мессиа, Сионы ^бХаан үүрд мөнх лугаа адил өргөн Тэнгэрийн ^аХад билээ; хаалгаар орж мөн надаар дээш ‘авирах хэн боловч хэзээ ч унах нь үгүй; иймийн тул, миний ярьсан тэд адислагдсан болой, учир нь тэд үүрдийн баяслын ^ддуунуудтайгаар урагш гарч ирэх болно.

54 Мөнхүү улиран тохиох дор Енох Их Эзэнд гуйн залбирч хэлэв: Хүний Хүү махан бодид хэзээ ирж, дэлхий амрах вэ? Эдгээр зүйлүүдийг надад үзүүлээч, би танаас гуйя.

55 Мөн Их Эзэн Еноход хэлэв: Хар, мөн тэрээр харж мөн хүмүүний маягаар “загалмайд өргөгдсөн Хүний ^бХүүг болгоов;

56 Мөн тэрээр чанга дуу хоолой сонсов; мөн тэнгэр бүрхэгдсэн байлаа; мөн Бурханы бүх бүтээл эмгэнэн гашуудав; мөн дэлхий “ёолов; мөн хаднууд цуурсан байв; мөн гэгээнтнүүд ^ббосч ирэн мөн алдар суугийн титэмтэйгээр,

48б Моисе 7:54, 58, 64.

в су Бузар, Бузар явдал.

51а Дуул. 104:6–9.

52а Моисе 8:2.

53а су Мессиа.

б Мат. 2:2;

2 Ниф. 10:14;

Алма 5:50;

С ба Г 128:22.

в Дуул. 71:3; 78:35;

Хил. 5:12. су Хад.

з 2 Ниф. 31:19–20.

д су Хөгжим.

55а 3 Ниф. 27:14.

су Цовдлуулалт.

б су Хүний Хүү.

56а Мат. 27:45, 50–51.

б су Амилуулалт.

Хүний Хүүгийн баруун гар талд хүндлэгдсэн байв;

57 Мөн “шоронд байсан” сүнс болгон урагш гарч ирэн, Бурханы баруун гар талд зогсож байв; мөн үлдсэн нь агуу их өдрийн шүүлтгийг хүртэл харанхуйн гинжинд хадгалагдсан байлаа.

58 Мөн Енох дахин уйлж, мөн Их Эзэнд хандан гуйн залбирч, хэлэв: Дэлхий хэзээ амрах вэ?

59 Мөн Хүний Хүү Эцэг өөд дээш ирэхийг Енох болгоов; мөн тэрээр Их Эзэнийг дуудан, хэллээ: Та дэлхий дээр дахин ирэхгүй гэж үү? Тиймийн тул, та бол Бурхан мөн би таныг мэднэ, мөн та надад тангараглаж, мөн бибээр таны Төрсөн Ганцын нэрээр асуух ёстой хэмээн надад зарлигласан буюу; та намайг бий болгосон билээ, мөн таны хаан сэнтийд эрхийг надад өөрөөс минь бус, харин та өөрийн нигүүлслээр дамжуулан надад өгсөн билээ; иймийн тул, та дэлхий дээр дахин ирэхгүй гэж үү? хэмээн би танаас асууж байна.

60 Мөн Их Эзэн Еноход хэлэв: Би амьдардгийн адил Ноагийн хүүхдүүдийн талаар та нарт өгсөн тангаргаа гүйцэлдүүлэхээр “эцсийн өд-

рүүдэд, ёс бусын хийгээд өс хонзонгийн өдрүүдэд би ирэх болно;

61 Мөн дэлхий “амрах тэр өдөр ирэх болно, гэвч тэр өдрийн өмнө тэнгэр” харанхуйлж, мөн харанхуйн “хөшиг дэлхийг бүрхэх болно; мөн тэнгэр хийгээд дэлхий сэгсрэгдэх болно; мөн хүмүүний үрсийн дунд агуу гай зовлон байх болно, гэвч өөрийн хүмүүсийг би “хамгаалан үлдэх болно;

62 Мөн “зөв шударга ёсыг тэнгэрээс доош би илгээх болно; мөн миний Төрсөн Ганцын тухай” гэрчлэхээр “дэлхийгээс” үнэнийг би илгээх болно; нас барагсдаас түүний “амилуулалтыг; тийм ээ, мөн тэрчлэн бүх хүмүүний амилуулалтыг; мөн миний хүмүүс бүсээ бүсэлж, мөн миний ирэлтийн цагийг урагш ширтэн хүлээж болохын тулд миний бэлтгэх тэр газар, Ариун Хотод миний сонгогдсон хүмүүсийг дэлхийн дөрвөн зүгээс “цуглуулахын тулд миний илгээх зөв шударга ёс хийгээд үнэн нь дэлхийг үер мэт арчих болгоно би; учир нь тэнд миний асар байх болно, мөн энэ нь Сион, “Шинэ Иерусалим хэмээн нэрлэгдэх болно.

56в Мат. 25:34.

г су Титэм;

Өргөмжлөл.

57а С ба Г 76:71–74;

88:99.

б су Сүнс.

60а су Эцсийн өдрүүд,

Хожмын өдрүүд.

61а су Дэлхий—

Дэлхийн эцсийн байдал.

б С ба Г 38:11–12;

112:23.

в су Хөшиг.

г 1 Ниф. 22:15–22;

2 Ниф. 30:10.

62а Дуул. 85:11.

су Сайн мэдээний

сэргээлт.

б су Гэрчлэл.

в Иса. 29:4.

г су Мормоны Ном.

д су Амилуулалт.

е су Израил—Израилын цугларалт.

ё су Шинэ

Иерусалим.

63 Мөн Их Эзэн Еноход хэлэв: Тэгээд чи болон чиний бүх “хот тэдэнтэй тэнд уулзах болно, мөн бид тэднийг цээжиндээ хүлээн авах болно, мөн тэд биднийг үзэх болно, мөн бид тэднийг тэвэрч, мөн тэд биднийг тэврэх болно, мөн бид бие биенээ үнсэх болно;

64 Мөн тэнд миний өргөө байх болно, мөн энэ нь миний бий болгосон бүх бүтээлтүүдээс урагш гарч ирэх Сион байх болно; мөн “мянган жилийн хугацаанд дэлхий амрах болно.

65 Мөнхүү улиран тохиох дор, мянган жилийн туршид дэлхий дээр зөв шударга ёсонд оршин суухаар Хүний Хүү эцсийн өдрүүдэд “ирэх тэр өдрийг Енох харав;

66 Гэвч тэр өдрийн өмнө тэрээр ёс бусчуудын дундах агуу гай зовлонг тэрээр харав; мөн зовлонд учирсан тэнгисийг, мөн ёс бусчуудын дээр ирэх Бүхнийг Чадагч Бурханы “шүүлтүүдийн учир айж эмээн урагш ширтэн хүлээх өөрсдийг нь “мохоох хүмүүний зүрх сэтгэлийг тэрээр тэрчлэн харав.

67 Мөн Их Эзэн бүх зүйлийг, бүр дэлхийн хязгаар дахийг Еноход үзүүлэв; мөн тэрээр зөв шударгыг үйлдэгчдийн өдрийг, тэдний гэтэлгэлийн

цагийг харж, мөн бүрэн “баяр баяслыг хүлээн авсан болой;

68 Мөн Енохын өдрүүд дэх “Сионы бүх өдрүүд гурван зуун жаранталан жил байв.

69 Мөн Енох бас түүний бүх хүмүүс Бурхантай хамт “алхалж байв, мөн тэрбээр Сионы дунд оршин сууж байсан болой; мөнхүү улиран тохиох дор Сион байхаа болив, учир нь Бурхан үүнийг өөрийн цээжинд дээш нь хүлээн авсан юм; мөн тэр цагаас хойш Сион Явчихсан хэмээх үг урагш гарч ирсэн ажгуу.

БҮЛЭГ 8

(1831 оны хоёрдугаар сар)

Метусела бошиглов—Ноа болон түүний хөвгүүд сайн мэдээг номлов—Агуу ёс бус явдал ноёрхов—Наманчлалын дуудлагад анхаарсангүй—Үерээр тохиох бүх маханбодийн устгалыг Бурхан тогтоов.

Мөн Енохын бүх өдрүүд дөрвөн зуун гучин жил байв.

2 Мөнхүү улиран тохиох дор Енохтой түүний хийсэн Их Эзэний гэрээнүүд биелэгдэхийн тулд, Енохын хүү “Метусела аваачигдаагүй ажээ; учир нь тэрээр Ноа түүний хэвлийн үр байх ёстой хэмээн Енохтой үнэнээр гэрээнд орсон байлаа.

63a Илч. 21:9–11;
С ба Г 45:11–12;
Моисе 7:19–21.

64a су Мянган жил.
б Моисе 7:48.

65a Иудей 1:14.

су Есүс Христийн
Хоёр дахь Ирэлт.

66a су Эцсийн шүүлт.

б Иса. 13:6–7.

67a су Баяр баясгалан.

68a Эхл. 5:23; Моисе 8:1.

69a Эхл. 5:24; Моисе 6:34.
су Аллах, Бурхантай
хамт алхах.

8 2a су Метусела.

3 Мөнхүү улиран тохиох дор түүний хэвлийгээс дэлхийн бүх хаант улсууд өсөн өндийх (Ноагаар дамжин) ёстой хэмээн Метусела бошиглож мөн тэрээр өөртөө алдар сууг олов.

4 Мөн уг нутагт их өлсгөлөн болов, мөн Их Эзэн дэлхийг зовлонг зүхлээр зүхэж, мөн үүний оршин суугчдаас олон нь үхэв.

5 Мөнхүү улиран тохиох дор Метусела нэг зуун наядолоон жил амьдарч, мөн Ламехыг төрүүлэв;

6 Мөн Метусела, тэрээр Ламехыг төрүүлсний дараа, долоон зуун наян хоёр жил амьдарч, мөн хөвгүүд хийгээд охидыг төрүүлэв.

7 Мөн Метуселагийн бүх өдрүүд өсөн зуун жаран өсөн жил байв, мөн тэрээр нас нөгчив.

8 Мөн Ламех нэг зуун наян хоёр жил амьдарч, мөн нэг хөвгүүн төрүүлэв;

9 Мөн тэрээр түүний нэрийг “Ноа хэмээн нэрлэж өгүүлрүүн: Их Эзэний ⁶зүхсэн газрын улмаас энэ хөвгүүн бидний ажил хийгээд бидний гарын хүчир хөдөлмөрийн талаар биднийг тайтгаруулах болно.

10 Мөн тэрээр Ноаг төрүүлсний дараа, Ламех таван зуун ерэнтаван жил амьдарч,

мөн хөвгүүд хийгээд охидыг төрүүлэв;

11 Мөн Ламехын бүх өдрүүд долоон зуун даландолоон жил байв, мөн тэрбээр нас нөгчив.

12 Мөн Ноа дөрвөн зуу мөн тавин настай байв, мөн Иафетыг ⁶төрүүлэв; мөн дочин хоёр жилийн хойно тэрээр Иафетын эх асан түүнээс ⁶Шемийг төрүүлсэн бөлгөө, мөн тэрээр таван зуун настай байхдаа ⁶Хамыг төрүүлэв.

13 Мөн “Ноа болон түүний хөвгүүд Их Эзэнийг ⁶анхаарч, мөн анхаарал тавьдаг байв, мөн тэд Бурханы ⁶хөвгүүд хэмээн нэрлэгддэг байв.

14 Мөн эдгээр хүмүүс дэлхийн гадаргуу дээр өсөн үржиж эхлэхэд, мөн тэдэнд охид төрсөн байлаа, тэдгээр охид гоо үзэсгэлэнтэйг хүмүүний ⁶хөвгүүд хараад мөн тэд тэднийг, бүр тэд шилж сонгон эхнэр болгон авцгаадаг байв.

15 Мөн Их Эзэн Ноад хэлэв: Чиний хөвгүүдийн охид өөрсдийгөө ⁶худалдлаа; учрыг болгоогтун хүмүүний хүүхдүүдийн эсрэг миний уур дүрэлзэж байна, учир нь тэд миний дуу хоолойг анхааран сонссонгүй.

16 Мөнхүү улиран тохиох

9а су Ноа, Библийн патриарх.
б Моисе 4:23.
12а Эхл. 5:32.
су Иафет.
б су Шем.
в су Хам.

13а С ба Г 138:41.
су Габриел.
б су Дуулгавартай байх, Дуулгавартай, Дуулгавартай дагах.
в су Бурханы

хөвгүүд охид.
14а Моисе 5:52.
15а су Гэрлэлт, Гэрлэх—Адил итгэлтэй хүмүүсийн хоорондох гэрлэлт.

дор Ноа бошиглож, мөн Бурханы зүйлүүдийг бүр энэ нь эхлэлд байсны адилаар заадаг байлаа.

17 Мөн Их Эзэн Ноад хэлэв: Миний Сүнс хүмүүний төлөө цаг ямагт “зүтгэх нь үгүй, учир нь тэрээр бүх “махан бодь үхнэ гэдгийг мэдэх болно; гэсэн ч түүний өдрүүд нэг зуун хорин жил байх болно; мөн хэрэв хүмүүн үл наманчлах аваас, би тэдэн дээр “үер илгээх болно.

18 Мөн тэр өдрүүдэд дэлхий дээр “аварга хүмүүс байв, мөн тэд Ноаг амь насыг нь бүрэлгэхээр эрэлхийлж байв; гэвч Их Эзэн Ноатай хамт байлаа, мөн Их Эзэний “хүч түүн дээр байв.

19 Мөн Их Эзэн өөрийн “жаягийн дагуу “Ноаг “томилж, мөн тэрээр урагш одож мөн өөрийнх нь Сайн мэдээг бүр энэ нь Еноход өгөгдсөний адилаар хүмүүний үрст “тунхаглах ёстой хэмээн түүнд зарлиглав.

20 Мөнхүү улиран тохиох дор Ноа тэд “наманчлах ёстой хэмээн хүмүүний үрсийг дуудав; гэвч тэд түүний үгсийг анхааран сонссонгүй;

21 Мөн тэрчлэн, тэд түүнийг

сонссоны дараа, тэд түүний өмнө хүрч ирэн, хэлсэн нь: Болгоогтун, бид Бурханы хүүхдүүд билээ, бид хүмүүний охидыг өөрсдөдөө аваагүй бил үү? Бид “идээгүй мөн уугаагүй, мөн гэрлэж мөн хадамд гарч байна уу? Мөн бидний эхнэрүүд бидэнд хүүхдүүдийг авчирдаг, мөн тэд бол эрт цагийн хүмүүс, агуу алдар нэрт хүмүүсийн нэгэн адил хүчирхэг хүмүүс билээ. Мөн тэд Ноагийн үгсийг анхааран сонссонгүй.

22 Мөн дэлхийд хүмүүсийн “ёсон бус нь агуу болсныг Бурхан харав; мөн хүн болгон зүрх сэтгэлийнхээ “бодлуудын төсөөлөлд хөөрч, үргэлжид хилэнцэт байв.

23 Мөнхүү улиран тохиох дор Ноа хүмүүст “номлохоо үргэлжлүүлэн, хэлдэг байв: Анхаарцгаа, мөн миний үгсэд анхаарал тавигтун;

24 “Итгэж мөн нүглүүдээсээ наманчлан мөн Бурханы Хүү, Есүс Христийн нэрээр, бүр бидний эцгүүдийн адил “баптисм хүртдэг байгтун, та нарт бүх зүйл “илэрхийлэгдэхийн тулд, та нар Ариун Сүнсийг хүлээн авах болно; мөн та нар үүнийг үл хийх аваас, үер та

17a Эхл. 6:3;
2 Ниф. 26:11;
Ифер 2:15;
С ба Г 1:33.
б 2 Ниф. 9:4.
су Махан бодь.
в Эхл. 7:4, 10;
Моисе 7:34.

18a Эхл. 6:4; Тоол. 13:33;
Иош. 17:15.
б су Хүч.

19a су Мелкизедек

санваар.
б Абр. 1:19.
в С ба Г 107:52.

су Томилох,
Томилолт.
г су Номлолын
ажил.

20a су Наманчлах,
Наманчлал.

21a Мат. 24:38–39;
ИС—А 1:41.

22a Эхл. 6:5;

Моисе 7:36–37.
б Мозая 4:30;
Алма 12:14.
су Бодлууд.

23a су Номлох.

24a су Итгэлтэй байх,
Итгэл.

б су Баптисм,
Баптисм хүртээх—
Баптисмд тэнцэх.

в 2 Ниф. 32:2–5.

нар дээр ирэх болно; гэсэн хэдий ч тэд анхааран сонссонгүй.

25 Мөн Ноа үүнд харамсаж, Их Эзэн дэлхий дээр хүнийг бий болгосонд түүний зүрх сэтгэл өвдөв, мөн энэ нь түүний сэтгэлийг эмзэглүүлэв.

26 Мөн Их Эзэн хэлэв: Би өөрийн бүтээсэн хүнийг, хүн амьтан хоёуланг нь, мөн мөлхөгч зүйлүүдийг, мөн агаарын жигүүртнүүдийг дэлхийн гадаргуугаас “устгах болно; би тэдгээрийг бүтээсний төлөө мөн би тэдгээрийг бий болгосны төлөө Ноа харамсдаг буюу; мөн тэрээр намайг дуудсан билээ; учир нь тэд түүний амийг эрэлхийлж байв.

27 Мөн ийн Ноа Их Эзэний мэлмийд “ач ивээлийг олсон

буюу; учир нь Ноа шударга мөн өөрийн үеийнхэн дотор “төгс хүн байв; мөн тэрээр, өөрийн гурван хүү Шем, Хам мөн Иафет нарын адил тэрчлэн Бурхантай хамт “алхалж байв.

28 Бурханы өмнө дэлхий “ялзарсан байв, мөн энэ нь хүчирхийллээр дүүрсэн байлаа.

29 Мөн Бурхан дэлхийг харав, мөн, болгоогтун, энэ нь ялзарсан байлаа, учир нь бүх маханбодь өөрийн замаар дэлхийд ялзарсан байв.

30 Мөн Бурхан Ноад хэлэв: Бүх махан бодийн төгсгөл мийн өмнө ирэх болно, учир нь дэлхий хүчирхийллээр дүүрээд байна, мөн болгоогтун бүх маханбодийг би дэлхийгээс “устгах болно.

26а су Дэлхий—
Дэлхийн
цэвэршилт.

27а су Ач ивээл.
б Эхл. 6:9.
в су Алхах, Бурхантай

хамт алхах.
28а Эхл. 6:11–13.
30а С ба Г 56:3.

АБРАХАМЫН НОМ

ИОСЕФ СМИТЭЭР ҮЙСНЭЭС ОРЧУУЛАГДСАН БОЛОЙ.

Египетийн газар доорх булшнаас бидний гарт орж ирсэн эртний *Езарим Цэдгүүдийн орчуулга оршвой. Египетэд байх үед нь түүний өөрийх нь гараар үйсэн дээр бичигдсэн Абрахамын бичээсүүд Абрахамын Ном хэмээн нэрлэгддэг. (History of the Church, 2:235–236, 348–351.)*

БҮЛЭГ 1

Абрахам патриархын жаягийн адислалуудыг эрэлхийлэв—Халдеи дахь хуурамч санваартнуудаар тэр мөрдөн хавчигдав—Иехова түүнийг аврав—Египетийн уугуул хүмүүс хийгээд засгийн газар тоймлогдов.

“ХАЛДЕИЧУУДЫН нутагт, **Х**эцгүүдийнхээ оршин суудаг газарт, ^аАбрахам, бибээр өөрийнхөө хувьд ^{ор}оршин суух өөр газар олох нь надад шаардлагатай байсныг олж харав;

2 Мөн агуу ^ааз жаргал хийгээд амар амгалан мөн ^бамралтыг тэнд өөртөө олсноор эцгүүдийн адислалуудыг мөн үүнийг гүйцэтгэхийн тулд томилогдох ёстой миний тэрхүү эрхийг би эрэлхийлсэн бөлгөө; бибээр өөрөө ^{зөв}шударга ёсыг дагагч байсан учраас, тэрчлэн илүү агуу ^{мэдлэгийг} эзэмшигч нэгэн мөн зөв шударга ёсыг агуу-

гаар дагагч байхыг хүсч, мөн агуу их мэдлэг эзэмшихийн тулд, мөн олон үндэстнүүдийн эцэг, амар амгалангийн хунтайж байхын тулд, мөн зааврууд хүлээн авахыг хүсч, мөн Бурханы зарлигуудыг сахихын тулд бибээр ^{эрх}бүхий хууль ёсны өвлөгч, эцгүүдэд хамаардаг зүйлийг атгагч ^{дээд}санваартан болсон билээ.

3 Энэ нь эцгүүдээс надад ^{олгогдсон} бөлгөө; энэ нь эцгүүдээс доош, цагийн эхлэлээс, тийм ээ, бүр эхлэлээс, эсвээс дэлхийн сууринаас өмнө бүр ^{ууган}төрөгчийн эсвээс ^{Адам} эсвээс анхны эцгээс байсан анхны хүний эрх нь энэ цагийг хүртэл эцгүүдээс доош дамжин надад ирсэн юм.

4 Эцгүүдэд үр удмынх нь талаар байх Бурханы томилолтын дагуу Санваарт томилогдох өөрийн ^{томилолтын} тулд би эрэлхийлж байлаа.

5 Миний ^{эцгүүд} өөрсдийн

1 ^а су Ур.

^б су Абрахам.

^в Үйлс 7:2–4.

2 ^а су Баяр баясгалан.

^б су Амрах.

^в су Зөв шударга,

Зөв шударга ёс.

2 ^с ба Г 42:61.

^{су} Мэдлэг.

3 ^д су Мелкизедек

санваар.

^е су Дээд

санваартан.

3 ^а ба Г 84:14.

6 ^с ба Г 68:17.

^{су} Ууган.

^в Мосе 1:34.

^{су} Адам.

4 ^а су Өвлөх эрх.

5 ^а Эхл. 12:1.



ТАЙЛБАР

Зураг 1. Их Эзэний Тэнгэр элч.

Зураг 2. Абрахам тахилын ширээн дээр хүлээстэй байгаа нь.

Зураг 3. Элкенагийн хиймэл шүтээн шүтэгч санваартан Абрахамыг тахил болгон өргөх гэж байгаа нь.

Зураг 4. Елкена, Либна Махмакра, Кораш болон Фарао бурхдын өмнө зогсож буй хиймэл шүтээн шүтэгч санваартны дэргэдэх тахилын ширээ.

Зураг 5. Элкенагийн хиймэл шүтээн бурхан.

Зураг 6. Либнагийн хиймэл шүтээн бурхан.

Зураг 7. Махмакрагийн хиймэл шүтээн бурхан.

Зураг 8. Корашийн хиймэл шүтээн бурхан.

Зураг 9. Фараогийн хиймэл шүтээн бурхан.

Зураг 10. Абрахам Египетэд.

Зураг 11. Египетчүүдийн ойлголтоор тэнгэрийн багануудыг төсөөлөн зурсан нь.

Зураг 12. Раукеянг, тэнгэр, эсвээс бидний толгой дээрх огторгуйн мандал гэсэн утгатай; харин энэ тохиолдолд, энэ сэдэвтэй холбогдуулан египетчүүд үүнийг Шаумау, дээр байх буюу тэнгэр гэдэг нь Шаумахиеем хэмээх еврей үгтэй утга дүйдэг ажээ.

зөв шударга ёсноос, өөрсдийнх нь Бурхан Их Эзэн тэдэнд өгсөн ариун зарлигуудаас, үнэн бурхныг мэддэггүй хүмүүсийн бурхдыг ⁶бишрэн шүтэхээр эргэж, миний дуу хоолойг анхаарахаас бүрмөсөн татгалзсан юм;

6 Учир нь тэдний зүрх сэтгэл хилэнцийг үйлдэхэд тавигдан, мөн Елкенагийн “бурхан, мөн Либнагийн бурхан, бас Махмакрагийн бурхан, бас Корашийн бурхан, мөн Египетийн хаан Фараогийн бурханд бүхлээрээ эргэсэн байлаа;

7 Тиймийн тул үнэн бурхныг мэддэггүй хүмүүс хүүхдүүдээ эдгээр хэлгүй хиймэл шүтээнүүдэд өргөн золиослоход тэд зүрх сэтгэлээ эргүүлж, мөн миний дуу хоолойг сонссонгүй, харин ч Елкенагийн санваартны гараар миний амь насыг бүрэлгэхээр оролдож байв. Елкенагийн санваартан нь тэрчлэн Фараогийн санваартан байлаа.

8 Эдүгээ, энэ цагт эдгээр хачин бурхдад өргөл өргөхийн тулд Халдеин нутагт баригдсан тахилын ширээн дээр эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийг Египетийн хаан, Фараогийн тахилд өргөдөг заншил байв.

9 Мөнхүү улиран тохиох дор тэрхүү санваартан Фараогийн бурханд, мөн тэрчлэн Шагреелын бурханд, бүр египетчүүдийн маягаар тахил

өргөдөг байв. Эдүгээ Шагреелын бурхан нь нар байлаа.

10 Бүр Олишемийн талын эхэн дэх Потифарын Толгой хэмээн нэрлэгддэг асан толгойн хажууд байдаг тахилын ширээн дээр Фараогийн санваартан хүүхдээр талархлын өргөл өргөдөг байв.

11 Эдүгээ, энэ санваартан “Хамын хэвлийгээс гарсан хааны шууд угсааны нэг нь асан Онитагийн гурван онгон охиныг энэ тахилын ширээн дээр өргөлд өргөсөн ажээ. Эдгээр онгон охид өөрсдийнхөө шударга журмын учир тахилд өргөгдсөн байлаа; тэд модон буюу чулуун бурхдыг шүтэн бишрэхийн тулд ⁶бөхийгөөгүй ажгуу, тиймийн тул тэд энэ тахилын ширээн дээр алагджээ, мөн энэ нь египетчүүдийн маягаар хийгдсэн аж.

12 Мөнхүү улиран тохиох дор тэд тэрчлэн намайг алж болохын тулд мөнөөх санваартнууд, онгон охидыг энэ тахилын ширээн дээр өргөсөнчлөн, харгис бурангуй санаагаа над дээр тавив; мөн та нар энэ тахилын ширээний талаар мэдлэгтэй байж болохын тулд бибээр энэ цэдгийн эхэн дэх танилцуулгад би та нарт иш татан хэлэх болно.

13 Энэ нь халдеичуудын дунд байсны адил, орны хэлбэрээр хийгддэг байв, мөн энэ нь Елкена, Либна, Махмакра, Кораш, мөн тэрчлэн

5б су Хиймэл шүтээн.
6а өх Абрахамын
Номны хуулбар

№1-д харуулсан
хуурмаг бурхад.
11а су Хам.

6 Дан. 3:13–18.

Египетийн хаан, Фараогийн бурхантай адил бурхдын өмнө зогсч байв.

14 Эдгээр бурхдын талаар та нар ойлголттой байж болохын тулд, Рахлеенос хэмээн халдеичуудаар нэрлэгддэг байсан зурган бичгийн утгыг илэрхийлсэн зургуудыг тэдгээрийн ерөнхий дүрслэлээр би та нарт эхэнд өгсөн билээ.

15 Мөн тэд намайг тахилд өргөж мөн амь насыг минь бүрэлгэж болохын тулд тэд над уруу гараа далайхад нь, болгоогтун, би өөрийн Бурхан Их Эзэнд дуу хоолойгоо өргөсөн буюу, мөн Их Эзэн “анхаарч мөн сонсов, мөн тэрбээр Бүхнийг Чадагчийн тухай үзэгдлээр намайг дүүргэв, мөн түүний дэргэдэх тэнгэр элч миний хажууд зогсож байв, мөн хүлээсийг минь тэр даруй ^бсуллав;

16 Мөн түүний дуу хоолой надад ирж; Абрахам, Абрахам, болгоогтун, миний “нэр Иехова билээ, мөн бибээр чамайг сонслоо, мөн чамайг чөлөөлж, мөн чамайг эцгийн чинь гэрээс, мөн өөрийн чинь бүх төрөл төрөгсдөөс холдуулан, чиний үл мэдэх харь ^бнутагт авчрахаар доош бууж ирлээ хэмээв;

17 Мөн энэ нь тэд Элкенагийн бурхан, мөн Либнагийн бурхан, мөн Махмакрагийн бурхан, мөн Корашийн бур-

хан мөн Египетийн хаан, Фараогийн бурхныг шүтэхийн тулд зүрх сэтгэлээ надаас буруулсных бөлгөө; тиймийн тул, тэдэнд айлчлахаар, мөн Абрахам хүү минь, амь насыг чинь бүрэлгэхээр чиний эсрэг гараа далайсан түүнийг устгахаар би доош бууж ирлээ.

18 Болгоогтун, би чамайг гараараа удирдах болно, мөн би өөрийн нэрийг, бүр чиний эцгийн “санваарыг чам дээр тавихын тулд би чамайг авах болно, мөн миний хүч чамд байх болно.

19 Энэ нь Ноад байсны нэгэн адил ийн чамд байх болно; харин чиний тохинууллаар дамжин миний “нэр дэлхийд үүрд мэдэгдэх болно, учир нь бибээр чиний Бурхан билээ.

20 Болгоогтун, Потифарын Толгой Халдеин “Урын нутагт байсан болой. Мөн Их Эзэн Елкенагийн тахилын ширээ, мөн уг нутагт бурхдыг эвдэж, мөн тэдгээрийг бүрмөсөн устган, бас мөнөөх санваартныг цохьж тэр үхэв; мөн Халдеид, Фараогийн ордонд агуу гашуудал болов; энэ нь Фараог хааны удмын цустай хаан гэсэн утга илэрхийлэх болгожээ.

21 Эдүгээ Египетийн энэ хаан бол “Хамын хэвлийн удам байлаа, мөн төрөлтөөр ^бканаанчуудын цусны хольцтой байлаа.

15a Моза 9:17–18.

б Абр. 2:13.

16a су Иехова.

б су Амлалтын нутаг.

18a су Санваар.

19a Эхл. 12:1–3.

20a Эхл. 11:28; Абр. 2:4.

21a Эхл. 10:6;

Дуул. 78:51; Моце 8:12.

б Моце 7:6–8.

су Канаан, Канаан хүн.

22 Энэ удмаас бүх египетчүүд салбарлан гарсан ажээ, мөн ийн канаанчуудын цус уг нутагт хадгалагдан үлджээ.

23 Хамын охин асан, мөн халдеи хэлээр “Египет гэсэн утгатай энэ нь хориглогдсон гэсэн утга бүхий Египтусын охин нэгэн эмэгтэйгээр Египетийн нутаг анх нээгдсэн ажээ.

24 Энэ эмэгтэй уг нутгийг нээхэд энэ нь усан дор байжээ, тэрээр хожим нь хөвгүүдээ үүн дээр суурьшуулжээ; мөн ийнхүү уг нутагт зүхлийг хадгалж үлдээсэн тэрхүү угсаатан Хамаас салбарлан үлдсэн ажгуу.

25 Эдүгээ Египетийн анхны засгийн газар Хамын охин Египтусын ууган хүү, Фараогоор үндэслэн байгуулагдсан байв, мөн энэ нь Хамын засгийн газрын арга маягаар, эцгийн эрхт ёсны дагуу байв.

26 Зөв шударга хүн асан Фарао өөрийн хаант улсыг үндэслэн байгуулж мөн өөрийн хүмүүсийг өөрийн бүх өдрүүдэд ухаалгаар хийгээд шударгаар шүүж, анхны эцгийн эрхт ёсны хаанчлалын өдрүүд дэх, бүр Адамын, мөн тэрчлэн эцэг нь түүнийг дэлхийн “адислалуудаар, мөн мэргэн ухааны адислалуудаар адисалсан боловч санваарт хамаарыхынх нь хувьд түүнийг зүхсэн Ноагийн хаанчлал дахь анхны

үеийн эцгүүдээр үндэслэн байгуулагдсан тэрхүү ариун жаягийг дуурайхыг эрхэмлэн эрэлхийлж байв.

27 Эдүгээ, Фараонууд Хамаар дамжуулан үүнийг Ноагаас шаргуугаар нэхэж болох хэдий ч Фарао, тэрээр “санваарын эрхтэй байж үл чадах удам угсааных байлаа, тиймийн тул миний эцэг тэдний хиймэл шүтээн шүтэх явдлаар зайцуулагдсан байв;

28 Гэвч, үүнээс хойш, бибээр өөрөөсөө арагш бүтээлтийн эхлэл уруу хөтлөх он дарааллыг зураглахыг хичээх болно, учир нь энэ цагийг иртэл миний хадгалж ирсэн “цэдгүүд миний гарт ирсэн билээ.

29 Эдүгээ, Елкенагийн санваартан цохигдож тэрээр үхсэний дараа, Халдеин нутгийн талаар надад хэлэгдсэн тэдгээр зүйлүүдийн гүйцэлдэлт, уг нутагт өлсгөлөн байх ёстой хэмээсэн нь ирсэн ажгуу.

30 Үүний улмаас өлсгөлөн Халдеин бүх нутгийг хамрав, мөн уг өлсгөлөнгийн улмаас миний эцэг зовлонт тарчлалыг амссан бөлгөө, мөн тэрээр, “амь насыг минь бүрэлгэх миний эсрэг төлөвлөсөн тэрхүү хилэнцээ нанманчилжээ.

31 Гэвч эцгүүдийн тухай, бүр патриархуудын, санваарын эрхийн талаарх цэдгүүдийг миний Бурхан Их Эзэн

23a су Египет.
26a су Адислах,
Адислагдах,

Адислал.
27a С ба Г АТ–2.
су Санваар.

28a Моце 6:5.
су Дурсамжийн ном.
30a Абр. 1:7.

миний гарт хадгалан үлдээсэн буюу; тиймийн тул, бүтээлтийн эхлэлийн тухай мэдлэг мөн тэрчлэн “гарагуудын тухай, бас однуудын тухай мэдлэгийг тэдгээр нь эцгүүдэд мэдүүлэгдсэний дагуу, би энэ өдрийг хүртэл хадгалж ирсэн билээ, мөн энэ цэдэг дээрх эдгээр зүйлүүдээс заримыг нь миний дараа ирэх өөрийн үр удмын ашиг тусын тулд бичихийг би хичээх болно.

БҮЛЭГ 2

Абрахам Канаан уруу явахын тулд Урыг орхив—Иехова Харанд түүн дээр хүрч ирэв—Сайн мэдээний бүх адислал түүний үр удамд мөн түүний үр удмаар дамжин бүгдэд амлагдав—Тэрээр Канаан уруу мөн дараа нь Египет уруу явав.

Эдүгээ Урын нутагт өлсгөлөнг Их Эзэн бүр гааруулсан буюу, үүний хэрээр, миний ах “Харан нас барав; харин миний эцэг ⁶Тера, Халдеи, Урын нутагт өдий хүртэл амьдарсаар байлаа.

2 Мөнхүү улиран тохиох дор, Абрахам, бибээр “Сарайг эхнэр болгон авав, миний ах ⁶Нахор Хараны охин асан Милкаг эхнэр болгон авлаа.

3 Эдүгээ Их Эзэн надад “хэлэв: Абрахам, чи улс орноосоо, мөн өөрийн ястнаас, мөн эцгийнхээ гэр орноос чамд миний үзүүлэх тэрхүү нутаг уруу гарч явагтун.

4 Тиймийн тул, бибээр Канааны нутаг уруу явахаар Халдеин, “Урын нутгийг орхин одов; мөн би ахынхаа хүү Лот, мөн түүний эхнэр, бас өөрийн эхнэр Сарайг авч явав; мөн тэрчлэн Харан хэмээн бидний нэрлэсэн нутаг уруу миний араас ⁶эцэг минь дагасан буюу.

5 Мөн өлсгөлөн төгсгөл болов. Мөн миний эцэг Харанд үлдэж тэндээ суув, учир нь Харанд олон мал сүрэг байв, мөн эцэг минь өөрийнхөө “хиймэл шүтээнд дахин эргэсэн бөлгөө, тиймийн тул тэрээр Харанд үргэлжлүүлэв.

6 Гэвч, Абрахам, бибээр, мөн миний ахын хүү “Лот Их Эзэнд залбирч, мөн Их Эзэн над дээр ⁶хүрч ирэн мөн надад хэлэв: Бос, мөн Лотыг өөртөө ав; учир нь би чамайг Харанаас гаргаж аван, мөн тэд миний дуу хоолойг анхаарах үед чиний дараах чиний үр удамд үүрдийн эзэмшлийн тулд миний өгөх харь ⁶нутагт чамайг миний “нэрийг гэрчлэх тохинуулагч болгохоор би зорьж байгаа болно.

31а Абр. 3:1–18.

2 1а Эхл. 11:28.

б Эхл. 11:24–26;

Шаст. дээд 1:26.

2а Эхл. 11:29.

су Сара.

б Эхл. 11:27; 22:20–24.

3а Эхл. 12:1;

Үйлс 7:1–3.

4а Нех. 9:7.

б Эхл. 11:31–32.

5а Иош. 24:2.

6а су Лот.

б Эхл. 17:1.

су Есүс Христ—

Христийн мөнх бус

байдлын өмнөх амьдрал.

в Эхл. 13:14–15; 17:8;

Ег. 33:1.

су Амлалтын нутаг.

г Эхл. 12:2–3;

Абр. 1:19.

7 Учир нь бибээр чиний Бурхан Их Эзэн билээ, би тэнгэрт оршин суудаг бөлгөө: дэлхий бол миний “хөлийн гишгүүр; би тэнгис дээгүүр мутраа сунгахад, энэ нь миний дуу хоолойг дуулгавартай дагадаг, салхи хийгээд галыг бибээр өөрийн ^бсүйх тэрэг болгосон буюу; би уулст — Эндээс явагтун — хэмээн хэлэхэд мөн болгоогтун, тэдгээр нь хуй салхиар, тэр даруй гэнэт хол зөөгддөг.

8 Миний нэр “Иехова, мөн бибээр эхлэлээс төгсгөлийг ^бмэднэ; тиймийн тул миний мутар чам дээр байх болно.

9 Мөн би чамаас агуу үндэстнийг бий болгох болно, мөн би чамайг хэр хэмжээнээс дээгүүр “адисалж, мөн нэрийг чинь бүх үндэстнүүдийн дунд агуу болгох болно, чибээр өөрийнхөө дараах үр удамдаа тэд өөрсдийн гарт энэ тохинуулал хийгээд ^бсанваарыг бүх үндэстнүүдэд гэрчлэх адислал байх болно;

10 Мөн чиний нэрээр дамжуулан би тэднийг адислах болно; учир нь энэ “Сайн мэдээг хүлээн авах болгон нь чиний нэрээр дуудагддаг

байх болно, мөн чиний ^бүр удам хэмээн тооцогддог байх болно, мөн босч зогсоод, тэдний “эцгийн хувьд, чамайг магтан дуулах болно;

11 Мөн чамайг магтан дуулах тэднийг би “адисалж мөн чамайг зүхэх тэднийг зүхэх болно, мөн чамд (энэ нь чиний санваарт) мөн чиний ^бүр удамд (энэ нь чиний санваар) буюу, учир нь энэхүү “эрх чамд, мөн чиний дараах үр удамд чинь үргэлжлэх болно хэмээх амлалтыг би чамд өгч байна (үүнийг шууд үр удам, эсвээс биеийнх нь үр удам хэмээн хэлдэг) дэлхийн бүх гэр бүл авралын адислалууд, бүр мөнх амьдралын адислалууд болох Сайн мэдээний адислалуудаар адислагдах болно.

12 Эдүгээ, Их Эзэн ярихаа надаас буцаан татсаны дараа, мөн түүний нүүр надаас буцаагдсаны дараа, би өөртөө хэлэв: Үйлчлэгч чинь таныг чин сэтгэлээсээ “эрэлхийлсэн бөлгөө; эдүгээ би таныг оллоо;

13 Намайг Елкенагийн бурхаас “чөлөөлөхөөр тэнгэр элчээ илгээсэн билээ та, бибээр таны дуу хоолойг анхаарах нь миний хувьд хамгийн сайн билээ, тиймийн тул, үйлч-

7a 1 Ниф. 17:39;
С ба Г 38:17.

б Иса. 66:15–16.

8a су Иехова.

б су Бүхнийг Мэдэгч.

9a 1 Ниф. 17:40;

2 Ниф. 29:14;

3 Ниф. 20:27;

Морм. 5:20.

су Абрахам—

Абрахамын үр удам.

б С ба Г 84:17–19;

Моисе 6:7.

су Мелкизедек санваар.

10a Гал. 3:7–9.

б Эхл. 13:16; Гал. 3:29;

2 Ниф. 30:2.

в су Патриарх,

Патриархын.

11a су Абрахамын

гэрээ.

б Иса. 61:9.

в су Өвлөх эрх;

Израил; Санваар.

12a С ба Г 88:63.

13a Абр. 1:15–17.

лэгч тань босч мөн амар амгаланд яваг.

14 Иймээс, Абрахам, бибээр Их Эзэн надад хэлсний дагуу гараад, мөн Лоттой хамт явав, Абрахам бибээр, Харанаас явах үедээ “жаран хоёр настай байв.

15 Мөн Халдеид, “Урт байх үедээ би эхнэр болгон авсан ⁶Сарайг, мөн өөрийн ахын хүү Лотыг, мөн өөрсдийн цуглуулсан бүх эд юмсаа, мөн Харанд өөрсдийн ⁶олж авсан бодгалиудыг авч явав, мөн Канааны нутаг уруу зорьсон замд гарч ирэв, мөн аян замд гарсан үедээ бид майханд сууж байлаа;

16 Тиймийн тул, Канааны нутагт очихын тулд бид Харанаас Жершоны замаар аялж явах үед үүрд мөнх нь бидний хамгаалалт мөн бидний “хад мөн бидний аврал байв.

17 Эдүгээ, Абрахам, бибээр Жершоны нутагт “тахилын ширээ барьж, мөн Их Эзэнд өргөл өргөв, мөн тэд үхэхгүй байж болохын тулд, ⁶өлсгөлөн миний эцгийн гэр орноос холдохын тулд залбирав.

18 Мөн тэгээд бид Жершоноос Шехемийн газар уруу одсон нутгаар дамжин өнгөрөв; энэ нь Морегийн талд байрласан байв, мөн бид

“канаанчуудын нутгийн хязгаарт аль хэдийн орж ирсэн байлаа, мөн тэнд Морегийн талд, би ⁶тахил өргөв, мөн Их Эзэнийг чин сэтгэлээсээ дуудав, учир нь хиймэл шүтээн шүтэгч энэ үндэстний нутагт бид аль хэдийн ороод ирчихсэн байлаа.

19 Мөн миний залбирлуудын хариуд Их Эзэн над дээр хүрч ирэн, мөн надад хэлэв: Чиний үр удамд би энэ “нутгийг өгөх болно.

20 Мөн Абрахам, бибээр Их Эзэнд барьсан тахилын ширээний газраас босч, мөн тэндээс “Бетелийн дорнод дахь уул уруу явав, мөн майхнаа тэнд босголоо, Бетел баруунтаа, мөн ⁶Хай зүүнтээ байх ажээ, мөн тэнд Их Эзэнд өөр нэг тахилын ширээ би барьж, мөн Их Эзэний нэрийг дахин ⁶дуудав.

21 Мөн Абрахам бибээр өмнөдийг чиглэн цааш аялсаар байв; мөн уг нутагт өлсгөлөн үргэлжилж байлаа, мөн Абрахам, бибээр Египет уруу доош явж, тэнд түр амьдрахаар шийдэв, учир нь өлсгөлөн нэн бэрх болов.

22 Мөнхүү улиран тохиох дор намайг Египет уруу орохоор ойртон явж байх үед Их Эзэн надад хэлэв: Болгоогтун, чиний эхнэр “Сарай

14a Эхл. 12:4–5.

15a су Ур.

б су Сара.

в су Хөрвүүлэг,
Хөрвөгч.

г су Канаан, Канаан
хүн.

16a су Хад.

17a су Өргөлийн

ширээ, тахилын
ширээ.

б Абр. 1:29.

18a Эхл. 12:6.

б су Золиослол.

19a Эхл. 13:12–15; 17:8;

Ег. 3:1–10;

Тоол. 34:2.

су Амлалтын нутаг.

20a су Бетел.

б Эхл. 13:3–4.

в Эхл. 12:8.

22a Эхл. 12:11–13.

харахад нэн гоо үзэсгэлэнтэй юм;

23 Тиймийн тул мөнхүү улиран тохиох дор египетчүүд түүнийг хараад — Тэр бол түүний эхнэр хэмээн тэд хэлэх болно; мөн тэд чамайг алах болно, харин тэд түүнийг амьд үлдээн аврах болно; тиймийн тул, чи ийм янзаар үйлдэхэд анхаарагтун:

24 Египетчүүдэд тэрээр өөрийгөө чиний дүү хэмээн хэлэг, мөн бодгаль чинь амьдрах болно.

25 Мөнхүү улиран тохиох дор Абрахам, бибээр Их Эзэний надад хэлсэн бүгдийг эхнэр Сарайдаа ярив—тиймийн тул чи миний дүү болой, надтай хамт байх нь чиний тусын тулд юм гэдгийг тэдэнд хэлэгтүн, би чамаас гуйя, мөн миний бодгаль чиний улмаас амьдрах болно.

БҮЛЭГ 3

Урим ба Туммимын аргаар нар, сар, оддын талаар Абрахам мэдэж авав—Их Эзэн сүнснүүдийн мөнхийн мөн чанарыг түүнд илчлэв—Дэлхийн өмнөх амьдрал, урьдчилсан томилолт, Бүтээлт, Гэтэлгэгчийг сонгосон хийгээд хүмүүний хоёр дахь байдлын тухай тэрээр мэдэж авав;

Мөн Халдеин Урт, миний Бурхан Их Эзэний надад өг-

сөн “Урим ба Туммим Абрахам надад байв.

2 Мөн би “оддыг, тэдгээр нь нэн агууг, түүнчлэн тэдгээрийн нэг нь Бурханы сэнтийд хамгийн ойрхон байсныг харав; мөн тэнд агуу олон нь үүнд ойрхон байлаа.

3 Мөн Их Эзэн надад хэлэв: Эдгээр нь тэргүүлдэг нь бөлгөө; мөн тэр агуу нэгийнх нь нэр “Колоб, учир нь энэ нь надад ойрхон байдаг, учир нь бибээр Их Эзэн чиний Бурхан: Дээр нь чиний зогсож байгаа түүний адил байдлаар харьяалагддаг тэдгээр бүгдийг тэргүүлэхээр үүнийг би байрлуулсан билээ.

4 Мөн Их Эзэн надад хэлэв, Колоб нь Урим ба Туммимаар, үүний хувьслууд дахь үүний цагууд хийгээд улирлуудын дагуу, Их Эзэний маягаар байсан бөлгөө; тийнхүү нэг хувьсал нь, үүний тооллын маягаар Их Эзэнд “нэг өдөр байв, энэ нь дээр нь чиний зогсож буй түүнд оноосон хугацааны дагуу нэг мянган ⁶жил болой. Энэ бол Колобын тооллын дагуух Их Эзэний цагийн тоолол ажээ.

5 Мөн Их Эзэн надад хэлэв: Өдрийг, бүр шөнийг захирдаг тэрнээс илүү бага тэрхүү бага гэрэл болох гараг нь дээр нь чиний зогсож буй түүнээс, тооллын хувьд дээ-

3 1а Ег. 28:30;
Мозая 8:13;
28:13–16;
ИС—Т 1:35.
су Урим ба

Туммим.
2а Абр. 1:31.
3а Хуулбар № 2, зураг
1-5ийг үз.
су Колоб.

4а Абр. 5:13.
6 Дуул. 90:4;
2 Петр 3:8.

гүүр буюу илүү бөлгөө, учир нь энэ нь бүр эмх цэгцэд илүү удаан хөдөлдөг; энэ нь дээр нь чиний зогсож буй дэлхийн улмаас энэ нь эмх цэгцэд байгаа билээ. Тиймийн тул, үүний цагийн тоолол нь үүний өдрүүдийн, мөн саруудын мөн жилүүдийн тоо лугаа адил тийм олон биш бөлгөө.

6 Мөн Их Эзэн надад хэлэв: Эдүгээ, Абрахам, эдгээр “хоёр бодит байдал оршин буй, болгоогтун чиний нүд үүнийг харж байгаа, тооллын цагуудыг мөн тогтоогдсон цаг, тийм ээ, дээр нь чиний зогсож буй дэлхийн тогтоогдсон цаг, мөн өдрийг захирахаар байрлуулагдсан илүү агуу гэрлийн тогтоогдсон цаг, мөн шөнийг захирахаар байрлуулагдсан илүү бага гэрлийн тогтоогдсон цагийг мэдэх нь чамд өгөгдсөн бөлгөө.

7 Эдүгээ илүү бага гэрлийн тогтоогдсон цаг нь үүний тооллын дагуу дээр нь чиний зогсож буй дэлхийн цагийн тооллоос илүү урт хугацаа юм.

8 Мөн эдгээр хоёр бодит байдал оршин буй газарт, тэнд тэдгээрийн дээр өөр нэг бодит байдал байх болно, тэр нь гэвэл, цагийн тоолол нь илүү урт хэвээр байх өөр нэг гараг байх болно;

9 Мөн тийн Их Эзэний тооллын дагуух Колоб болох тэрхүү Колобт чамайг ойрхон

ирэх хүртэл, нэг гарагийн дээрх нөгөөгийнх нь цагийн тоолол байх болно; дээр нь чиний зогсож буйтай мөн адил “жаягт багтдаг, тэдгээрт харьяалагддаг тэдгээр бүх гарагуудыг тэргүүлэхээр Бурханы сэнтийд ойрхон байрлуулагдсан тэрхүү Колоб бөлгөө.

10 Мөн чамайг Бурханы сэнтийд ойрхон ирэх хүртэл гэрэл өгөхөөр байрлуулагдсан бүх оддын тогтоогдсон цагийг мэдэх нь чамд өгөгддөг бөлгөө.

11 Тийн, Абрахам бибээр Их Эзэнтэй, нүүр нүүрээрээ тулан, нэг хүн нөгөөтэйгөө ярьж байгаа мэт Бурхантай “ярьж байлаа; мөн тэрбээр өөрийнх нь гараар хийгдсэн ажлуудын тухай надад ярив;

12 Мөн тэрбээр надад хэлэв: Хүү минь, хүү минь (мөн түүний гар сунгаастай байв), болгоогтун би эдгээр бүгдийг чамд үзүүлэх болно. Мөн тэрбээр гараа миний нүдэн дээр тавьж, мөн түүний гар хийсэн тэдгээр зүйлүүдийг би харав, тэдгээр нь олон байлаа; мөн тэдгээр нь миний нүдний өмнө өсөн үржиж байв, мөн би тэдгээрийн төгсгөлийг харж чадсангүй.

13 Мөн тэрээр надад хэлэв: Энэ бол нар болох Шинеха. Мөн тэрбээр надад хэлэв: Од болох Кокоб. Мөн тэрбээр надад хэлэв: Сар болох Олеа. Мөн тэрбээр надад хэлэв: Одод эсвээс тэнгэрийн ман-

далд байгаа бүх агуу гэрлүүд гэсэн утгатай Кокаубеам.

14 Мөн Их Эзэн: Би чамайг, мөн чиний дараах “үр удмыг чинь эдэн лугаа адил ^бөсгөн үржүүлэх болно; мөн хэрэв чи элсний “тоог тоолж чадах аваас, чиний үр удмын тоо ийм байх болно хэмээн эдгээр үгсийг надад ярьсан тэр үе нь шөнийн цаг байв.

15 Мөн Их Эзэн надад хэлэв: Абрахам, эдгээр бүх үгсийг тунхаглаж болохын тулд, чамайг Египет уруу явахаас өмнө эдгээр зүйлүүдийг би чамд үзүүлэе.

16 Хэрэв хоёр зүйл орших аваас, мөн нэг нь нөгөөгөөсөө дээгүүр байх аваас, тэдгээрийн дээгүүр илүү агуу зүйлүүд байх болно; тиймийн тул “Колоб нь чиний үзсэн бүх Кокаубеамаас хамгийн агуу нь болой, учир нь энэ нь надад хамгийн ойрхон байдаг бөлгөө.

17 Эдүгээ, хэрэв хоёр зүйл, нэг нь нөгөөгийнхөө дээгүүр байх аваас, мөн сар нь дэлхийн дээгүүр байх аваас, тэгвэл нэг гараг буюу од үүний дээгүүр оршиж болох нь байж болох буюу; мөн Их Эзэн, чиний Бурхан хийхээр зүрх сэтгэлдээ шийдсэнээ тэрээр “гүйцэлдүүлэхгүй байх нь үгүй билээ.

18 Тэрбээр мөнөөх илүү агуу

одыг бий болгосон байж болох буюу; үүн лугаа, тэрчлэн, хэрэв хоёр сүнс байх аваас, мөн нэг нь нөгөөгөөсөө оюуны илүү өндөр хөгжилтэй байх аваас, чухам эдгээр сүнснүүд, нэг нь нөгөөгөөсөө оюун нь өндөр хөгжилтэй байхаас үл хамааран эхлэлгүй буюу; тэд өмнө нь оршин байсан болой, тэд төгсгөлгүй байх болно, тэд дараа нь оршин байх болно, учир нь тэд “гнолаум буюу мөнх бөлгөө.

19 Мөн Их Эзэн надад хэлэв: Нэг нь нөгөөгөөсөө оюуны илүү өндөр хөгжилтэй хоёр сүнс байхад тэдгээрээс оюуны илүү өндөр хөгжилтэй өөр нэг нь байдаг эдгээр хоёр бодит байдал оршдог бөлгөө; бибээр Их Эзэн, чиний Бурхан билээ, бибээр тэд бүгдээс “илүү өндөр оюуны хөгжилтэй болой.

20 Их Эзэн, чиний Бурхан чамайг Элкенагийн санваартны гараас “чөлөөлөхөөр тэнгэр элчээ илгээсэн бөлгөө.

21 Би тэд бүгдийн дунд оршин суудаг; Би эдүгээ, тиймийн тул, тэд бүгдээс онцгойрон ялгардаг миний мэргэн байдал миний гарын хийсэн “ажлуудыг чамд үзүүлэхээр чам уруу доош бууж ирлээ, учир нь би дээр тэнгэрт, мөн доор дэлхийд, бүх ^бмэргэн ухаан хийгээд


14a Эхл. 13:16;
С ба Г 132:30.
б Абр. 2:9.
в Эхл. 22:17;
Хосеа 1:10.
16a Абр. 3:3.

17a Иов 9:4–12.
18a Гнолаум гэдэг нь мөнх гэсэн утгатай еврей үгийн галиг юм.
19a Иса. 55:8–9.

су Бүхнийг Мэдэгч.
20a Абр. 1:15.
21a С ба Г 88:45–47;
Моце 1:27–29.
б су Мэргэн ухаан.

АБРАХАМЫН НОМНООС АВСАН ХУУЛБАР

Дугаар 2



ТАЙЛБАР

Зураг 1. Селестиел буюу Бурханы орших газарт хамгийн ойрхон Колоб нь анхны бүтээлтийг төлөөлдөг. Тэргүүлэхэд эхнийх, цагийн хэмжүүрт хамаарахад эцсийнх буюу. Селестиел цаг нь нэг өдөр нь нэг үзүүр тохойтой тэнцдэг селестиеэл цагийн дагуух хэмжүүр буюу. Колоб дахь нэг өдөр нь египетчүүд жаж-ох-эх хэмээн нэрлэдэг энэ дэлхийн хэмжүүрээр мянган жилтэй тэнцүү болой.

Зураг 2. Их Эзэнд зориулан босгосон тахилын ширээн дээр тахил өргөх үед Бурханаас Абрахамд илчилснээр Селестиел буюу Бурхан оршдог газарт ойр, египетчүүд Олиблиш хэмээн нэрлэдэг дараагийн их тэргүүлэх бүтээлт нь тэрчлэн тэрээр бусад гарагуудад хамаарах хүчний түлхүүрийг атган Колобын дэргэд оршдог.

Зураг 3. Сүр хүч хийгээд эрх мэдлээр хувцаслан, тэргүүн дээрээ мөнхийн гэрлийн титэмтэйгээр сэнтийдээ заларч буй Бурханыг төлөөлүүлэхээр хийгджээ; мөн тэрчлэн Еденийн Цэцэрлэгт Адамд, мөн түүнчлэн Сет, Ноа, Мелкизедек, Абрахам мөн санваар илчлэгдсэн тэд бүгдэд илчлэгдсэнчлэн, Ариун санваарын агуу Түлхүүр-үгсийг төлөөлүүлдэг.

Зураг 4. Огторгуй буюу тэнгэрийн мандал гэсэн утгатай Раукееяанг хэмээх еврей үгтэй утга дүйдэг; тэрчлэн египет хэлэнд нэг мянга гэсэн утгатай тоон зураг; эргэлтээрээ болон цагийн хэмжүүрээр Колобтой тэнцүү Олиблишийн цагийн хэмжүүртэй утга дүйдэг.

Зураг 5. Египет хэлэнд Эниш-го-он-дош гэж дуудагддаг; энэ бол тэрчлэн тэргүүлэгч гарагуудын нэг юм, мөн египетчүүд нар хэмээн, мөн их Түлхүүр, өөрөөр хэлбэл, мөн Флоесе буюу Сар, Дэлхий ба Нар нь өөрсдийн жил тутмын эргэлтэд тэрчлэн байдгийн адилаар бусад арван таван тогтсон гараг буюу одны дунд тэргүүлдэг, тэргүүлэгч хүч буюу Кае-е-ванрашийн аргаар дамжуулан гэрлээ Колобоос авдаг хэмээн ярьдаг ажээ. Энэ гараг хүчээ Кли-флос-ис-эс буюу Колобын эргэлтүүдээс гэрэл хүлээж авдаг, 22 ба 23-ын тоонуудаар харуулсан одод Хак-кокау-беамын аргаар дамжуулан хүлээж авдаг.

Зураг 6. Энэ дэлхийг дөрвөн зүгээр нь харуулсан нь.

Зураг 7. Тэнгэрээр дамжуулан санваарын агуу Түлхүүр-үгсийг илчлэлтээс сэнтийдээ залран буй Бурханыг; мөн түүнчлэн, тагтаа хэлбэрээр Абрахам уруу ирж буй Ариун Сүнсний тэмдгийг харуулсан нь.

Зураг 8. Дэлхийд илчлэгдэж үл болох бичээсүүдийг агуулжээ; гэвч энэ нь Бурханы Ариун Сүмд байх ёстой ажээ.

Зураг 9. Эдүгээ цагт илчлэгдэх ёсгүй.

Зураг 10. Мөн адил.

Зураг 11. Мөн адил. Хэрэв дэлхий эдгээр тоонуудыг мэдэж чадах аваас, тийн байтугай. Амен.

Зураг 12,13,14,15,16,17,18,19,20 мөн 21 нь Их Эзэний өөрийнх нь тогтоосон цагт өгөгдөх болно.

Дээрх орчуулга нь эдүгээ үед бидэнд буй аль нэгэн эрхийн хэмжээнд л өгөгдсөн болно.

туйлын анхааралд захирдаг буюу, бүх оюун билгийн дээгүүр чиний мэлмий эхлэлээс харлаа; чиний харсан бүх оюун билгүүдийн дунд эхлэлд би доош бууж ирсэн бөлгөө.

22 Эдүгээ дэлхий байхаас “өмнө зохион байгуулагдсан” оюун билгүүдийг Абрахам надад, Их Эзэн үзүүлэв; мөн эд бүгдийн дунд “нэр төртэй хийгээд агуу суутнууд олон байв;

23 Мөн сайн байсан тэдгээр бодгалиудыг Бурхан харав, мөн тэрбээр тэдний дунд байлаа, мөн тэрбээр хэлэв: Эднийг би захирагчдаа болгох болно; учир нь тэрбээр сүнс асан тэдний дунд зогсож байв, мөн тэрбээр сайн байсан тэднийг харав; мөн тэрбээр надад хэлэв: Абрахам, чи тэдний нэг болой; чи төрөхөөсөө өмнө “сонгогдсон билээ.

24 Мөн тэдний дунд Бурхантай адилхан “нэгэн зогсож байв, мөн тэрээр өөртэйгөө хамт байсан тэдэнд хэлэв: Бид доошоо явцгаах болно, учир нь тэнд орон зай буй,

мөн бид эдгээр материалуудаас авч, мөн дээр нь тэд оршин сууж болох “дэлхийг” бид хийх болно;

25 Мөн Их Эзэн, тэдний Бурхан тэдэнд зарлиглах бүх зүйл юуг ч гэсэн тэд “хийх нь үү гэдгийг харахын тулд үүгээр бид тэднийг” нотлох болно;

26 Мөн өөрсдийн “анхны байдлыг хадгалдаг тэдэн дээр нэмэгдэх болно; мөн өөрсдийн анхны байдлыг хадгалдаггүй тэд, өөрсдийн анхны байдлыг хадгалдаг тэдэнтэй хамт нэг хаант улсад алдар сууг олж чадах нь үгүй бөлгөө; мөн өөрсдийн “хоёр дахь байдлыг хадгалдаг тэдний тэргүүн дээр” алдар суу үүрд мөн мөнхөд нэмэгдэх болно.

27 Мөн “Их Эзэн хэлэв: Хэнийг илгээх вэ би? Мөн “Хүний Хүүтэй адил нэгэн хариулав: Би энд байна, намайг илгээгтүн. Мөн “өөр нэг нь хариулж мөн хэлэв: Би энд байна, намайг илгээгтүн. Мөн Их Эзэн хэлэв: Эхнийхийг би илгээх болно.

28 Мөн “хоёр дахь нь ууртай байв, мөн өөрийн анхны

22a су Тэнгэр дэх Зөвлөл; Мөнх бус байдлын өмнөх амьдрал.
б су Оюуны өндөр хөгжил.
в С ба Г 138:55.
23a Иса. 49:1–5; Иер. 1:5.
су Сонгох, Сонгосон, Сонгогдсон; Урьдчилсан томилолт.

24a су Анх төрсөн.
б су Газар дэлхий— Хүмүүнд зориулагдан бүтээгдэв.
в су Бүтээх, Бүтээл.
25a су Дуулгавартай байх, Дуулгавартай, Дуулгавартай дагах.
б С ба Г 98:12–14; 124:55.
су Сонгох эрх; Гэтэлгэлийн

төлөвлөгөө.
26a Иудей 1:6.
б су Мөнх бус, Мөнх бус байдал.
в Тит. 1:2.
су Алдар суу.
27a су Бурхан, Бурхан тэргүүтэн — Эцэг Бурхан.
б су Есүс Христ; Хүний Хүү.
в Моисе 4:1–2.
28a су Чөтгөр.

байдлыг хадгалсан нь үгүй; мөн тэр өдөр ⁶олон нь түүний араас дагав.

БҮЛЭГ 4

Дэлхийн бүтээлт хийгээд түүн дээрх бүх амьдралыг Бурхад төлөвлөв—Бүтээлтийн зургаан өдөрт зориулсан тэдний төлөвлөгөө толилуулагдав.

Мөн тэгээд Их Эзэн хэлэв: Доошоо явцгаая. Мөн тэд “эхлэлд доошоо явцгаав, мөн тэд, тэд бол Бурхад байв, тэнгэр ба дэлхийг ⁶зохион байгуулж мөн бий болгов.

2 Мөн дэлхий нь, үүнийг бий болгосны дараа энэ нь хоосон мөн эзгүй байв, учир нь тэд дэлхийгээс өөр ямар нэг юм бий болгоогүй байлаа; мөн гүний гадаргуу дээгүүр харанхуй ноёрхож байв, мөн Бурхадын Сүнс усны гадаргуу дээгүүр “тогтож байлаа.

3 Мөн тэд (Бурхад) хэлэв: Гэрэл байг; мөн гэрэл байв.

4 Мөн тэд (Бурхад) гэрлийг ухаарав, учир нь энэ нь хурц гэрэлтэй байлаа; мөн тэд гэрлийг салгав, эсвээс үүнийг харанхуйгаас салгасан байхаар болгов.

5 Мөн Бурхад тэрхүү гэрлийг Өдөр хэмээн нэрлэв, мөн харанхуйг тэд Шөнө хэмээн нэрлэв. Мөнхүү улиран тохиох дор үдшээс өглөө

хүртлэхийг тэд шөнө хэмээн нэрлэв; өглөөнөөс үдэш хүртлэхийг тэд өдөр хэмээн нэрлэв; мөн үүнийг өдөр болон шөнө хэмээн нэрлэсэн нь эхнийх буюу эхлэл байлаа.

6 Мөн Бурхад тэрчлэн хэлэв: Усны дунд “огторгуй байг, мөн энэ нь их усыг их уснаас салгаг.

7 Мөн огторгуйн дор байсан их усыг уг огторгуйн дээр байсан их уснаас салгасан байхыг Бурхад огторгуйд тушаав; мөн энэ нь үүнчлэн, бүр тэдний тушааснаар байв.

8 Мөн Бурхад тэрхүү огторгуйг, “Тэнгэр хэмээн нэрлэв. Мөнхүү улиран тохиох дор шөнө хэмээн тэдний нэрлэсэн нь үдшээс өглөөг хүртэл байлаа; мөнхүү улиран тохиох дор өдөр хэмээн тэдний нэрлэсэн нь өглөөнөөс үдэш хүртэл байлаа; мөн энэ нь шөнө ба өдөр хэмээн тэдний нэрлэсэн хоёр дахь ⁶цаг хугацаа байв.

9 Мөн Бурхад тушааж, хэлсэн нь: Тэнгэрийн доорх “уснууд нэг газарт ⁶нэг дор цуглуулагдаг, мөн хуурай газар гарч ирэг; мөн энэ нь тэдний тушааснаар байв;

10 Мөн Бурхад хуурай газрыг Дэлхий хэмээн нэрийдэв; мөн их ус нэг дор цуглуулагдсаныг тэд “Агуу Их Ус хэмээн нэрийдэв; мөн тэдгээр нь дуулгавартай байсныг Бурхад харав.

28б су Мөхлийн хүүхдүүд.

4 1а Эхл. 1:1; Моце 2:1.

б су Бүтээх, Бүтээл.

2а Эхл. 1:2; Моце 2:2.

6а Эхл. 1:4–6; Моце 2:4.

8а су Тэнгэр.

б Эхл. 1:8.

9а Амос 9:6; Моце 2:7.

б Эхл. 1:9.

10а Эхл. 1:10; Абр. 4:22.

11 Мөн Бурхад хэлэв: “Өвс, үр гаргагч ургамал, үр нь газар дээр өөрийнхөө адилаар өөртөө өөрийнхөө төрлөөр жимс гаргагч жимсний мод урагш авчрахад газрыг бэлтгэцгээе; мөн энэ нь үүнчлэн, бүр тэдний тушааснаар байв.

12 Мөн Бурхад, өөрийнхөө үрнээс өвсийг урагш авчрахаар, мөн өөрийнхөө үрнээс өөрийнхөө төрлөөр үрийг гаргагч ургамал авчрах ургамлыг авчрахын тулд газрыг мөн өөрийнхөө төрлөөр, үр нь зөвхөн өөртөө, мөн адилхныг, өөрийнхөө үрнээс жимс гаргагч модыг урагш авчрахын тулд газрыг зохион байгуулав; мөн тэдгээр нь дуулгавартай байсныг Бурхад харав.

13 Мөнхүү улиран тохиох дор, тэд өдрүүдийг тоолов; үдшээс өглөөг хүртлэхийг тэд шөнө хэмээн нэрлэв; мөнхүү улиран тохиох дор, өглөөнөөс үдшийг хүртлэхийг тэд өдөр хэмээн нэрлэв; мөн энэ нь гурав дахь цаг хугацаа байв.

14 Мөн Бурхад тэнгэрийн огторгуй дахь “гэрлүүдийг зохион байгуулж, мөн тэдгээрийг шөнөөс өдрийг салгахаар болгов; мөн тэдгээрийг тэмдгүүд хийгээд улирлуудын тулд, мөн өдрүүд хийгээд жилүүдийн тулд байхаар зохион байгуулав;

15 Мөн тэдгээрийг тэнгэрийн огторгуй дахь гэрлүүд байхын тулд, дэлхийд гэрэл

өгөхөөр зохион байгуулав; мөн энэ нь үүнчлэн байв.

16 Мөн Бурхад хоёр агуу гэрлийг, “их гэрэл нь өдрийг захирахаар, бага гэрэл нь шөнийг захирахаар зохион байгуулав; бага гэрэлтэй хамт тэд тэрчлэн оддыг байрлуулав;

17 Мөн дэлхийд гэрэл өгөхөөр, мөн өдрийг хийгээд шөнийг захирахаар, мөн харанхуйгаас гэрлийг салгасан байхаар тэнгэрийн огторгуйд Бурхад тэдгээрийг байрлуулав.

18 Мөн Бурхад өөрсдийн тушаасан тэдгээр зүйлүүд, тэдгээр нь дуулгавартай байхыг хүртэл харав.

19 Мөнхүү улиран тохиох дор үдшээс өглөөг хүртэлх нь шөнө байв; мөнхүү улиран тохиох дор өглөөнөөс үдшийг хүртэлх нь өдөр байв; мөн энэ нь дөрөв дэх цаг хугацаа байв.

20 Мөн Бурхад хэлэв: Амьдрал бүхий хөдлөгч амьтдыг элбэг дэлбэгээр урагш авчрахын тулд уснуудыг бэлтгэцгээе; мөн тэнгэрийн огторгуйд дэлхий дээгүүр тэдгээр нь нисч болохын тулд жигүүртнүүдийг.

21 Мөн тэдгээр нь агуу том “халимнууд, мөн хөдөлдөг аливаа амьтдыг их ус өөрсдийнх нь төрлөөр, элбэг дэлбэгээр авчирч болохын тулд Бурхад их усыг бэлтгэв; мөн далавч бүхий жигүүртэн болгоныг өөрсдийнх нь төрлөөр

буюу. Мөн Бурхад тэдгээр нь дуулгавартай байсныг мөн өөрсдийнх нь төлөвлөгөө сайн байсныг харав.

22 Мөн Бурхад хэлэв: Бид тэдгээрийг адисалж, мөн тэдгээрийг үр төлтэй байж, мөн өсөн үржиж, мөн тэнгисийн ус буюу “агуу их усыг дүүргэхээр болгон, мөн жигүүртнүүдийг дэлхий дээр өсөн үржиж байхаар болгоно.

23 Мөнхүү улиран тохиох дор үдшээс өглөө хүртлэхийг тэд шөнө хэмээн нэрлэв; мөнхүү улиран тохиох дор өглөөнөөс үдэш хүртлэхийг тэд өдөр хэмээн нэрлэв; мөн энэ нь тав дахь цаг хугацаа байв.

24 Мөн амьд бүтээлтийг өөрсдийнх нь төрлөөр, мал хийгээд мөлхөгч зүйлүүд, мөн дэлхийн зэрлэг амьтдыг өөрсдийнх нь төрлөөр урагш авчрахаар газрыг “Бурхад бэлтгэв; мөн энэ нь үүнчлэн тэдний хэлсэнчлэн байв.

25 Мөн зэрлэг амьтдыг өөрсдийнх нь төрлөөр, мөн мал адгуусыг өөрсдийнх нь төрлөөр, мөн дэлхий дээгүүр мөлхөгч юм болгоныг өөрийнх нь төрлөөр урагш авчрахаар Бурхад дэлхийг зохион байгуулав; мөн тэдгээр нь дуулгавартай байсныг Бурхад харав.

26 Мөн Бурхад өөр хоорондоо “зөвлөлдөж тэгээд хэлэв: Доошоо явцгааж мөн өөрсдийн ^бдүр төрхөөр, өөрсдийн адил төстэй байдлаар хүнийг

“бий болгоё; мөн тэнгисийн загаснуудын дээр, бас агаарын жигүүртнүүдийн дээр, мөн мал адгуусны дээр, бас бүх дэлхий дээр, мөн дэлхий дээгүүр мөлхдөг мөлхөгч амьтан болгоны дээрх ноёрхлыг бид тэдэнд өгөх болно.

27 Ингээд “Бурхад өөрсдийнхөө дүр төрхөөр, Бурхадын дүр төрхөөр хүнийг зохион байгуулахаар тэд түүнийг, эрэгтэй мөн эмэгтэйг бий болгохоор, тэднийг бий болгохоор тэд явцгаав.

28 Мөн Бурхад хэлэв: Бид тэднийг адислах болно. Мөн Бурхад айлдав: Бид тэднийг үр төлтэй байж мөн өсөн үржиж, мөн дэлхийг бүрхэн, мөн үүнийг захирч, мөн тэнгисийн загасны дээр, бас агаарын жигүүртний дээр, мөн дэлхий дээгүүр хөдлөн явдаг амьтан болгоны дээр ноёрхолтой байхаар болгох болно.

29 Мөн Бурхад хэлэв: Болгоогтун, бүх дэлхийн гадаргуу дээр ирэх, үр тээгч ургамал болгоныг, бид тэдэнд өгөх болно; мөн өөр дээрээ жимстэй болгоныг; тийм ээ, тэдэнд үр гаргагч модны жимсийг бид өгөх болно; энэ нь тэдний “хоол хүнсний тулд байх болно.

30 Мөн дэлхийн зэрлэг амьтан болгонд, мөн агаарын жигүүртэн бүрд, мөн дэлхий дээгүүр мөлхдөг амьтан болгонд, болгоогтун, бид тэдгээрт амьдралыг өгөх болно;

22a Абр. 4:10.

24a су Бурхан, Бурхан тэргүүтэн.

26a су Зөвлөгөө.

б Моисе 6:8–10.
в су Хүмүүн, Хүмүүс.

27a Эхл. 1:26–27;

Абр. 5:7

29a Эхл. 1:29–30.

мөн тэрчлэн ногоон ургамал болгоныг бид тэдэнд хоол тэжээлийн тулд өгөх болно, мөн эдгээр бүх зүйл ийн зохион байгуулагдах болно.

31 Мөн Бурхад хэлэв: Бид хэлсэн бүх зүйлээ хийж, мөн зохион байгуулах болно, мөн болгоогтун, тэдгээр нь туйлын дуулгавартай байх болно. Мөнхүү улиран тохиох дор энэ нь үдшээс өглөө хүртэл байсныг тэд шөнө хэмээн нэрлэв; мөнхүү улиран тохиох дор энэ нь өглөөнөөс үдэш хүртэл байсныг тэд өдөр хэмээн нэрлэв; тэд “зургаа дахь цаг хугацааг тоолов.

БҮЛЭГ 5

Бурхад бүх зүйлийн бүтээлтийг төлөвлөснөө дуусгав—Тэд төлөвлөгөөнүүдийг дагуу Бүтээлтийг тохиолгон авчрав—Адам амьд бүтээл бүрийг нэрлэв.

Мөн ийн бид тэнгэр хийгээд дэлхий, тэдгээрийн бүх олныг дуусгах болно.

2 Мөн Бурхад өөр хоорондоо хэлэлцэв: “Долоо дахь цаг хугацаанд бид зөвлөлдсөн ажлаа дуусгах болно; мөн долоо дахь цаг хугацаанд бид зөвлөлдсөн бүх ажлаасаа амрах болно.

3 Мөн тэрхүү долоо дахь цаг хугацаанд тэд (Бурхад) бий болгохоор өөр хоорондоо

зөвлөлдөн бүх ажлуудаасаа тэд “амарч байхаар Бурхад шийдэв; мөн үүнийг ⁶ариусгасан бөлгөө. Мөн тэнгэр хийгээд дэлхийг бий болгохоор тэд өөр хоорондоо зөвлөлдсөн тэр удаа дахь тэдний шийдвэрүүд ийн байлаа.

4 Мөн Бурхад доош ирж мөн тэнгэр хийгээд дэлхийн эдгээр үеийг бий болгов, тэдгээр нь бий болгогдсон тэр өдөр Бурхад дэлхий хийгээд тэнгэрийг бий болгосон бөлгөө,

5 Мөн үүнийг дэлхийд байхаас “өмнө талбайн ургамал бүрийн талаар тэдний айлдсан тэр бүхний дагуу, мөн талбайн ургамал бүр энэ нь ургахаас өмнө байв; учир нь Бурхад тэдгээрийг хийхээр тэд зөвлөлдөж байх үед дэлхий дээр бороо орохоор болгосон нь үгүй байв, мөн газар боловсруулах хүнийг бий болгоогүй байжээ.

6 Харин дэлхийгээс манан дээш хөөрч, тэгээд газрын бүх гадаргыг усалжээ.

7 Мөн “Бурхад газрын ⁶тоосноос хүнийг бий болгож, мөн түүний ⁶сүнсийг (тэр нь, хүмүүний сүнс болой) хийв, мөн үүнийг түүнд хийсэн бөлгөө; мөн амьдралын амьсгалыг түүний хамрын нүхээр амьсгалуулав, тэгээд хүн амьд ⁶бодгаль болов.

8 Мөн Бурхад “Еденд зүүн

31a Ег. 31:17.

5 2a су Хүндэтгэлийн өдөр.

3a Ег. 20:8–11;
Мозая 13:16–19.

б С ба Г 77:12.

5a су Сүнсний бүтээл.
7a Абр. 4:26–31.

б Моце 4:25; 6:59.

в Эхл. 2:7; С ба Г 93:33.

су Мөнх бус
байдлын өмнөх
амьдрал; Сүнс.

2 су Бие.
8a су Еден.



ТАЙЛБАР

Зураг 1. Хааны эелдэг ялдам байдлаар, тэргүүн дээрээ хааны титэмтэйгээр, Тэнгэр дэх их Тэргүүлийн бэлэгдэл болсон санваарыг төлөөлөн, гартаа шударга ёс хийгээд шүүлтийн очирт таягтайгаар Фараогийн хаан сэнтийд залран буй Абрахам.

Зураг 2. Нэр нь тэргүүн дээр нь дүрс бичгээр өгөгдсөн Фарао хаан.

Зураг 3. Хуулбар дугаар 1-ийн Зураг 10-т өгүүлсэнчлэн Абрахам Египетэд байгааг харуулсан нь.

Зураг 4. Гарынх нь дээр бичигдсэнээр Египетийн хаан, Фараогийн хан хүү.

Зураг 5. Хааны шадар үйлчлэгчдийн нэг Шулем хэмээн гарынх нь дээрх дүрс бичгүүдээр төлөөлүүлжээ.

Зураг 6. Олимла, ханхүүд харьяалагддаг нэгэн боол.

Абрахам хааны ордонд Одон орны зарчмуудыг тайлбарлаж байгаа нь.

талд цэцэрлэг тарьж, мөн тэнд мөнөөх хүнийг тавьж, өөрсдийнхөө бий болгосон биенд сүнсийг нь тэд оруулсан бөлгөө.

9 Мөн харахад аятайхан хийгээд хоол хүнсний тул сайн мод болгоныг, “амьдралын модыг, тэрчлэн, цэцэрлэгийн гол дунд, мөн сайн ба муугийн мэдлэгийн модыг Бурхад газраас ургах болгов.

10 Цэцэрлэгийг услах нэгэн гол Еденээс урсдаг байв, мөн тэндээс энэ нь салаалж, мөн дөрвөн голын эх болдог байлаа.

11 Мөн Бурхад хүнийг авч, мөн үүнийг арчлан тордож, мөн харж хандаж байхын тулд Еденийн Цэцэрлэгт түүнийг тавив.

12 Мөн Бурхад хүнд зарлиглаж, хэлсэн нь: Цэцэрлэгийн мод болгоноос чи чөлөөтэйгөөр идэж болно,

13 Харин сайн ба муугийн мэдлэгийн модноос, чи үүнээс идэх ёсгүй; учир нь чи үүнээс идсэн үед чи гарцаагүй үхэх болно. Эдүгээ, Абрахам бибээр, энэ нь “Колобын цагийн дагуух Их Эзэний ⁶цагийн дагуу байсныг харав; учир нь Бурхад Адамд түүний тооллыг хараахан өгөөгүй байжээ.

14 Мөн Бурхад хэлэв: Хүнд туслагчийг хийцгээе, учир нь хүн ганцаар байх нь сайн биш байна, тиймийн тул түүнд зориулж бид туслагчийг бий болгох болно.

15 Мөн Бурхад “Адамыг гүн нойронд автсан байхаар болгов; тэгээд тэрээр унтжээ, мөн тэд түүний хавиргануудаас нэгийг авч, мөн үүний оронд махаар таглажээ;

16 Мөн Бурхад хүнээс авсан мөнөөх хавирганаас тэд “эмэгтэй хүнийг бий болгож, мөн түүнийг эрэгтэй хүн дээр авчрав.

17 Мөн Адам хэлэв: Энэ бол миний ясны яс, мөн махны мах бөлгөө; эдүгээ тэрээр Эмэгтэй Хүн хэмээн дуудагдах болно, учир нь тэрээр Эр хүнээс тасдан авагдсан юм;

18 Тиймийн тул, эр хүн эцэг, мөн эхээ орхин, мөн эхнэртэйгээ “нэгдэн нийлж, тэгээд тэд ⁶нэг махан бодь байх болно.

19 Мөн тэд хоёул, эр хүн болон түүний эхнэр, нүцгэн байв, мөн ичдэггүй байв.

20 Мөн Бурхад газраас тэжээмэл амьтан болгоныг, мөн агаарын жигүүртэн бүрийг бий болгож, мөн тэдгээрийг Адам юу гэж нэрлэхийг харахаар авчрав; мөн амьд бүтээл бүрийг Адам юу гэж нэрлэнэв, тэр нь тэдгээрийн нэр байх ёстой.

21 Мөн Адам бүх мал адгууст, агаарын жигүүртнүүдэд, тэжээмэл амьтан болгонд нэр өгөв; мөн Адамын хувьд, түүнд туслагч бий болсон байлаа.

9а су Амьдралын мод.
13а Абр. 3:2–4.
су Колоб.

б 2 Петр 3:8.
15а су Адам.
16а су Ева.

18а С ба Г 42:22;
49:15–16.
б су Гэрлэлт, Гэрлэх.

ИОСЕФ СМИТ — МАТАЙ

1831 онд Бошиглогч Иосеф Смитэд илчлэгдсэн Библийн орчуулгаас авсан хэсэг оршвой: Матай 23:39 ба бүлэг 24.

Иерусалимын ойртож буй устгалыг Есүс угтан хэлэв—Тэрбээр түүнчлэн Хүний Хүүгийн хоёрдахь ирэлт, мөн ёс бусчуудын устгалын тухай өгүүлдэг.

Учир нь энэ цагаас хойш та нар намайг харахгүй, мөн: Их Эзэний нэрээр тэнгэрийн үүлэн дунд, мөн бүх ариун тэнгэр элчүүд түүнтэй хамт “ирэх тэрбээр адислагдсан болой хэмээн та нар хэлэх хүртлээ, бошиглогчдоор түүний тухай бичигдсэн тэр нь бибээр билээ гэдгийг мэдэх нь үгүйг би та нарт хэлж байна. Тэгээд шавь нар нь түүнийг ⁶Бурханы баруун гар талд алдаршиж мөн титэм хүртсэний дараа тэрээр дэлхийд дахин ирэх ёстойг ойлгосон болой.

2 Мөн Есүс гарч ирэн, мөн ариун сүмээс гарч явав; мөн шавь нар нь: Эзээн, Тэдгээр нь доош хаягдаж мөн та нарт эзгүйрч үлдэх болно хэмээн та өөрийн хэлсэн ариун сүмийн барилгуудын талаар бидэнд үзүүлнэ үү хэмээн хэлж, түүнийг сонсохын тулд, түүн уруу хүрч очив.

3 Мөн Есүс тэдэнд хэлэв: Та нар эдгээр бүх зүйлийг харахгүй мөн та нар тэдгээрийг ойлгохгүй байна гэж үү? Үнэнээр би та нарт хэлнэ, энэ ариун сүм дээр, нэг “чулуу нөгөө дээрээ үлдэхгүйгээр доош хаягдах болно.

4 Мөн Есүс тэднийг орхиж, мөн Чидуны “Уулан дээр гарав. Мөн түүнийг Чидуны Уулан дээр суухад, шавь нар нь түүн уруу ганцаарчлан хүрч ирцгээн: Ариун сүмийн, мөн иудейчүүдийн устгалын талаар таны айлдсан эдгээр зүйлүүд хэзээ тохиохыг бидэнд хэлнэ үү; мөн таны ⁶ирэлтийн, мөн дэлхийн ⁶төгсгөлийн, эсвээс дэлхийн төгсгөл болох ⁷ёс бусчуудын устгалын ⁸тэмдэг нь юу вэ? хэмээн асуув.

5 Мөн Есүс хариулж, мөн тэдэнд хэлэв: Хүмүүн та нарыг мэхлэхгүйн тулд анхааралтай байгтун;

6 Учир нь би Христ байна хэмээн хэлж, олон нь ирэх болно, мөн олныг мэхлэх болно;

7 Тийнхүү тэд та нарыг “зовлон зүдгүүрт унагаж, мөн та нарыг алах болно, мөн та нар,

1 1a Мат. 26:64;

Үйлс 1:11.

б су Бурхан, Бурхан тэргүүтэн.

3a Лук 19:44.

4a су Чидуны уул.

б су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

⁶ су Дэлхий—
Дэлхийн төгсгөл.

² Мал. 4:1;

С ба Г 133:64–74.

су Ёс бус, Ёс бус

байдал.

д Лук 21:7–36;

С ба Г 45:16–75.

су Эцсийн өдрүүд,

Хожмын өдрүүд;

Цаг хугацааны

тэмдгүүд.

7a 1 Петр 4:12–14.

миний нэрний улмаас бүх үндэстнээр ^бүзэн ядагдах болно;

8 Мөн тийнхүү олон нь гомдоогдох болно, мөн нэг нь нөгөөгөөсөө урвах болно, мөн нэг нь нөгөөгөө үзэн ядах болно;

9 Мөн олон хуурамч бошиглогч гарч ирэх болно, мөн олныг мэхлэх болно;

10 Мөн алдас газар авсны улмаас, олны “хайр хөрөх болно;

11 Гэвч гуйвшгүй хэвээр үлдэх тэрбээр дийлэгдэх нь үгүй, мөнхүү тэр нь аврагдах болно.

12 “Иерусалимын устгалын талаар Бошиглогч ^дДаниелаар хэлэгдсэн эзгүйрлийн “жигшүүрийг, тийнхүү, та нар үзэх үед, тэгвэл та нар ‘ариун газарт зогсох ёстой; уншдаг хэн боловч тэрээр ойлгог.

13 Тийнхүү Иудейд байгаа тэд “уулс уруу зугтаг;

14 Дээвэр дээр байгаа тэрбээр зугтаг, гэрээсээ юу ч авахаар бүү эргэг;

15 Мөн талбай дээр байх тэрбээр хувцсаа авахаар бүү эргэг;

16 “Хүүхэдтэй тэдэнд, мөн тэдгээр өдрүүдэд хүүхдээ хөхүүлэх тэдэнд халаг;

17 Тиймийн тул, та нарын зугтах нь өвлөөр байхгүйн тулд, Хүндэтгэлийн өдөр байхгүйн тулд та нар Их Эзэнд залбирагтун;

18 Учир нь тийнхүү, тэдгээр өдрүүдэд, тэдний хаант улсын эхлэлээс энэ цагийг хүртэл урьд нь Израил дээр Бурханаас илгээгдэж байгаагүй, мөн Израил дээр дахин хэзээ ч илгээгдэх нь үгүй тийм агуу гай зовлон “иудейчүүд дээр, мөн ^бИерусалимын оршин суугчид дээр тохиох болно.

19 Тэдэнд тохиосон бүх зүйл нь тэдэн дээр ирэх тэрхүү уй гашуугийн зөвхөн эхлэл нь бөлгөө.

20 Мөн тэдгээр өдрүүд богиносгогдохоос бусдаар, тэдний махан бодиос нэг нь ч аврагдах нь үгүй, гэвч сонгогдсон хүмүүсийн төлөө, гэрээний дагуу, тэдгээр өдрүүд богиносгогдох болно.

21 Болгоогтун, иудейчүүдийн талаар эдгээр зүйлүүдийг би та нарт ярилаа; мөн дахин, Иерусалим дээр тохиох тэдгээр өдрүүдийн тэрхүү гай зовлонгийн дараа, хэрэв хэн нэгэн нь, Харагтун, энд эсвээс тэнд Христ байна хэмээн хэлэх аваас, түүнд бүү итгэ;

22 Учир нь тэдгээр өдрүүдэд түүнчлэн хуурамч Христүүд, мөн хуурамч бошиглогчид гарч ирэх болно, мөн агуу тэмдгүүд хийгээд гайхалтай зүйлүүдийг үзүүлэх болно, ингэхийн хэрээр, хэрэв боломжтой бол, гэрээний дагуу сонгогдсон тэд байх тэрхүү

7б су Хавчих,
Хавчлага.
10а С ба Г 45:27.
12а су Иерусалим.

б су Даниел.
в Дан. 12:11.
г С ба Г 101:22–25.
13а С ба Г 133:13.

16а Лук 23:29–30.
18а су Иудейчүүд.
б Зех. 12; 14:1–5.

сонгогдсон хүмүүсийг мэхлэх болно.

23 Болгоогтун, “сонгогдсон хүмүүсийн төлөө би эдгээр зүйлүүдийг та нарт ярилаа; мөн та нар тэрчлэн дайнуудын тухай, бас дайны цуурхлуудын тухай сонсох болно; та нар тэвдэн сандрахгүй байхаа мэдэгтүн, учир нь миний ярьсан бүхэн тохиох ёстой; гэвч төгсгөл хараахан болоогүй байна.

24 Болгоогтун, би та нарт өмнө нь ярьсан билээ;

25 Иймийн тул, хэрэв тэд та нарт: Болгоогтун, тэрээр цөлд байна хэмээн хэлэх аваас; урагш бүү явагтун; болгоогтун, тэрээр дотоод өрөөнд байна гэвэл; үүнд бүү итгэ;

26 Учир нь өглөөний гэрэл “дорно зүгээс мандаж мөн гагцхүү өрнөд зүгт гэрлээ цацруулж, мөн бүх дэлхийг бүрхдэг лугаа адил, мөн Хүний Хүүгийн ирэлт нь үүнчлэн байх бөлгөө.

27 Мөн эдүгээ би нэг сургаалт зүйрлэлийг та нарт өгүүлье. Болгоогтун, хүүр нь хаана байна, бүргэдүүд тэнд хамтдаа цугладаг; яг үүнчлэн миний сонгосон хүмүүс дэлхийн дөрвөн зүгээс “цугла-рах болно.

28 Мөн тэд дайнуудын тухай, мөн дайны цуурхлуудын тухай сонсох болно.

29 Болгоогтун бибээр өө-

рийн сонгосон хүмүүсийн төлөө ярьж байна; учир нь үндэстэн үндэстний эсрэг, мөн хаант улс хаант улсын эсрэг босох болно; янз бүрийн газарт “өлсгөлөн, өвчин тахал, бас газар хөдлөлт байх болно.

30 Мөн дахин, алдас газар авсны улмаас, хүмүүний хайр хөрөх болно; гэвч үл дийлэгдэх тэрбээр, мөнхүү тэр нь аврагдах болно.

31 Мөн дахин, бүх үндэстэнд гэрч байхын тулд Хаант улсын Сайн мэдээ бүх “дэлхийд номлогдох болно, мөн тэгээд төгсгөл, эсвээс ёс бусчуудын устгал ирэх болно;

32 Мөн дахин, бошиглогч Даниелаар яригдсан эзгүйрлийн жигшүүрт хэрэг гүйцэлдэх болно.

33 Мөн тэдгээр өдрүүдийн гай зовлонгийн яг дараахан нь “нар харанхуйлж, мөн сар гэрлээ өгөхөө больж, мөн одод тэнгэрээс унаж, мөн тэнгэрийн хүчнүүд сэгсрэгдэх болно.

34 Үнэнээр, би та нарт хэлж байна, эдгээр зүйлүүд үзүүлэгдэх энэ үе, та нарт миний ярьсан бүхэн гүйцэлдэх хүртэл алга болох нь үгүй бөлгөө.

35 Гэсэн хэдий ч, тэнгэр хийгээд газар алга болох тэрхүү өдрүүд ирэх болно, гэвч, миний “үгс алга болох нь үгүй, харин бүх зүйл гүйцэлдэх болно.

36 Мөн, би өмнө хэлсэнч-

23a су Сонгох.
б С ба Г 45:26.
26a Езек. 43:2.
27a су Израил—

Израилын
цугларалт.
29a С ба Г 43:24–25.
31a Мат. 28:19–20.

33a Иоел 2:10;
С ба Г 29:14.
35a С ба Г 1:38.

лэн, тэдгээр өдрүүдийн “гай зовлонгийн дараа, мөн тэнгэрийн хүчнүүд сэгсрэгдэх болно, ингээд Хүний Хүүгийн тэмдэг тэнгэрт гарч ирэх болно, тэгээд дэлхийн бүх овог аймгууд гашуудах болно, мөн сүр хүч хийгээд агуу алдар суутайгаар тэнгэрийн үүлэн дунд ^бирж буй Хүний Хүүг тэд харах болно;

37 Мөн миний “үгийг нөөцлөх хэн боловч хууртагдах нь үгүй, учир нь Хүний Хүү ирэх болно, мөн бүрээгээ агуугаар дуугаргасан ^бтэнгэр элчүүдээ өөрийнхөө өмнө тэрбээр илгээх болно, мөн тэд түүний сонгосон хүмүүсийн үлдсэнийг нь дөрвөн зүгээс, тэнгэрийн нэг хязгаараас нөгөөд хамтад нь ^ццуглуулах болно.

38 Эдүгээ “инжир модны тухай сургаалт зүйрлэлийг мэдэж авагтун—Мөчрүүд нь нялх хэвээр байхад, мөн энэ нь нахиалж эхлэхэд, зун ойртож буйг та нар мэддэг билээ;

39 Миний сонгосон хүмүүс яг үүнчлэн, эдгээр бүх зүйлүүдийг тэд хараад, тэрбээр ойрхон буйг, бүр хаалган дээр байгааг тэд мэдэх болно;

40 Гэвч тэр өдрийн, мөн цагийн тухай хэн ч, гагцхүү Эцэгээс минь өөр хэн ч тэнгэр дэх Бурханы тэнгэр элчүүд ч үл ^амэдэх бөлгөө.

41 Гэвч “Ноагийн өдрүүдэд

энэ нь байсанчлан, мөн энэ нь Хүний Хүүгийн ирэлтэд тэрчлэн байх болно;

42 Учир нь “үерийн өмнө байсан тэдгээр өдрүүдэд байсны адилаар энэ нь тэдэнд байх болно; учир нь Ноа хөвөгч авдарт орсон тэрхүү өдрийг хүртэл мөн тэд идэж, ууж, хуримлаж мөн хадамд гаргаж байсан бөлгөө;

43 Мөн үер ирэхийг хүртэл мэдсэн нь үгүй, мөн тэднийг бүгдийг нь урсган одсон буюу, мөн Хүний Хүүгийн ирэлт бас үүнчлэн байх болно.

44 Тийнхүү “эцсийн өдрүүдэд, талбайд байх хоёроос нэг нь аваачигдан, мөн нөгөөх нь ^бүлдэх болно хэмээн бичигдсэн тэрхүү зүйл гүйцэлдэх болно;

45 Тээрэм эргүүлж байх хоёрын нэг нь аваачигдан, мөн нөгөөх нь үлдэх болно;

46 Мөн нэгд хэлснийгээ бүх хүмүүст хэлнэ би, тиймийн тул, “сэрэмжтэй байгтун, учир нь Их Эзэн чинь ямар цагт ирэхийг та нар мэдэх нь үгүй.

47 Гэвч үүнийг мэд, хэрэв гэрийн сайн эзэн ямар цагт хулгайч ирж болохыг мэддэг байсан бол, тэрээр сэрэмжилж, мөн гэр орноо эвдүүлэхийг зөвшөөрөлгүй, харин бэлэн байж болох буюу.

48 Тиймийн тул, та нар

36a ИС—А 1:18.

б су Есүс Христийн Хоёр дахь Ирэлт.

37a су Судрууд.

б С ба Г 29:11–15.

в су Израил—

Израилын цугларалт.

38a С ба Г 35:16.

40a С ба Г 39:20–21; 49:7.

41a Эхл. 6:5.

42a су Ноагийн

үеийн үер.

44a су Эцсийн өдрүүд, Хожмын өдрүүд.

б Зех. 13:8.

46a су Харар, Харуул.

үүнчлэн бэлэн байгтун, учир нь Хүний Хүү та нарын бодоогүй тийм цагт ирнэ.

49 Тэгвэл, эзэн нь гэрийнхээ захирагч болгосон “үнэнч итгэлтэй хийгээд ухаалаг ямар зарц зохих цагт нь тэдэнд зоог барих билээ?

50 Тэрбээр ирэх үедээ, үүнчлэн үйлдэж буйг эзэн нь олж харсан тэрхүү зарц адислагдсан болой, мөн тэрбээр түүнийг эд хогшлынхоо захирагч болгоно гэдгийг би үнэнээр та нарт хэлж байна.

51 Харин хэрэв хилэнцэт зарц зүрх сэтгэлдээ: Эзэн минь ирэлтээ “хойшлуулна хэмээн хэлэх аваас,

52 Мөн өөрийн нөхөд—зарц нарыг цохьж мөн согтуу-

чуудтай хамт идэж, мөн ууж эхлэх болно,

53 Тэрхүү зарцын эзэн өөрийг нь тэрээр хүлээж байгаагүй тэр өдөр, мөн түүний сэрэмжгүй байсан тэр цагт ирэх болно,

54 Мөн түүнийг тасар цавчин, мөн хоёр нүүр гаргагчдын хамт түүнд хувийг нь хүртээх болно, тэгээд уйлж мөн шүдээ “хавирах нь байх болно.

55 Мөн тэд хүмүүсийн дундаас тусгаарлагдах болно хэмээн хэлсэн Мосегийн бошиглолын дагуу, ийнхүү ёс бусчуудын “төгсгөл ирнэ. Хэдийгээр дэлхийн төгсгөл хараахан болоогүй ч, харин ойрхон мөн ойрхон байна.

49a су Итгэл.
51a С ба Г 45:26.
54a Мат. 8:12.

55a 2 Ниф. 30:10;
С ба Г 1:9–10; 29:17.
су Дэлхий—

Дэлхийн төгсгөл.

ИОСЕФ СМИТ — ТҮҮХ

БОШИГЛОГЧ ИОСЕФ СМИТИЙН ТҮҮХЭЭС АВСАН ХЭСГҮҮД ОРШВОЙ

History of the Church, Боть 1, Бүлэг 1-ээс 5

Иосеф Смит өөрийн өвөг дээдэс, гэр бүлийн гишүүд, мөн тэдний анх оршин сууж байсан газруудын тухай өгүүлжээ—Шашны талаар ер бусын сонирхол баруун Нью-Йоркт өрнөв—Тэрээр Иаковаар чиглүүлэгдэн мэргэн ухааныг эрэлхийлэхээр шийдэв—Эцэг мөн Хүү хурч ирэн, мөн Иосеф өөрийн бошиглогчийн тохинуулалд дуудагдав. (Шүлэг 1–20).

ЕСҮС Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ^бөсөлт хийгээд дэвшилтэй холбоотойгоор хилэнцэт санаа бодолтой хийгээд зальхай хүмүүсээс тогтмол хэвлэлд нийтэлсэн олон нийтлэл бүгдээрээ, эдгээрийг зохиогчид Сүмийг шинж чанарынх нь хувьд мөн дэлхий дэх үүний дэвшил хөгжлийн эсрэг ширүүн дайралт хийж буйн улмаас, энэ түүхийг бичиж, хүмүүсийн буруу ойлголтыг залруулах мөн өөртөө хийгээд Сүмд аль алинд нь холбогдох баримтуудыг болсон байдлаар нь үнэнийг эрэлхийлэгч бүхэнд мэдэгдэхээс аргагүйд хүрэв, учир юун гэвэл ийм баримтууд надад буй бөлгөө.

2 Энэ Сүмд хийгээд үнэн ба зөв шударга ёсонд холбогдох нилээд баримтуудыг, болсон байдлаар нь, эсвээс, дурдсан Сүм “зохион байгуулагдсанаас хойшхи найман жилд [1838] эдүгээ болж байгаа үйл явдлуудыг би энэ түүхэнд толилуулах болно.

3 Бидний Их Эзэний нэг мянга найман зуун таван онд, арванхоёрдугаар сарын хорин гурав дахь өдөр Вермонт муж улсын Виндсор гүнлэгийн Шарон хотхонд “би төрсөн Намайг аравтай юм уу, тэр орчим настай байхад миний эцэг, Ахмад ^бИосеф Смит Вермонт муж улсыг орхиж, тэгээд Нью-Йорк муж улсын Онтарио (одоогийн Ваине) гүнлэгийн Палмирад шилжсэн аж. Эцэг минь Палмирад ирснээс хойш дөрөв орчим жилийн дараа, мөн Онтарио гүнлэг дэх Манчестерт гэр бүлийнхээ хамт шилжжээ—

4 Түүний гэр бүл арван нэгэн амаас бүрддэг байв, тухайлбал, миний эцэг “Иосеф Смит; миний ^бэх Люси Смит (гэрлэхээсээ өмнө түүний нэр Мак, Соломон Макийн охин байв); миний ах нар, “Алвин

1 *1a* су Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм.
б су Сайн мэдээний

сэргээлт.
2a С ба Г 20:1.
3a су Бага Иосеф Смит
б 2 Ниф. 3:15.

4a су Ахмад Иосеф Смит.
б су Смит, Люси Мак.
в С ба Г 137:5–6.

(1823 оны арваннэгдүгээр сарын 19-нд, 26 насандаа нас барсан), “Хайрум, би, миний эрэгтэй дүү нар”^а Самуел Харрисон, Виллям, Дон Карлос; миний эмэгтэй дүү нар Софрония, Катерин, мөн Люси болой.

5 Биднийг Манчестерт шилжиж ирснээс хойш хоёр дахь жилд нь бидний амьдарч байсан газарт шашны сэдвээр ер бусын үймээн хэсэг хугацаанд өрнөсөн билээ. Энэ нь методистуудаас эхэлсэн хэдий ч удалгүй улс орны шашны бүх урсгалуудын дунд нийтлэг болов. Чухамдаа, улс орны бүх бүс нутаг үүнд татагдан ороод байв, мөн үй олон хүмүүс өөрсдийгөө хүмүүсийн дунд багагүй үймээн хийгээд хагарлыг бий болгож байсан шашны янз бүрийн бүлгүүдэд нэгдэн, зарим нь “Ийшээ харагтун”, бас бусад нь “Тийшээ харагтун” хэмээн хашгирч байв. Зарим нь методист итгэлийн төлөө, зарим нь пресбитриений төлөө, бас зарим нь баптистын төлөө мэтгэлцэж байв.

6 Учир нь, эдгээр янз бүрийн итгэлүүдэд хөрвүүлэгдэхдээ илэрхийлж байсан хөрвөгчдийн агуу хайр нь хүн бүрийг хөрвүүлэхийн тулд тэд аль таалагдсан шашныхаа бүлэгт орог хэмээн тэд тааламжтайгаар хэлж байсан нь шашны талаарх энэ ер бусын талбарт идэвхтэйгээр гарч ирсэн янз

бүрийн тохинуулагчдын их хүчин чармайлт байсан хэдий ч, хөрвөгчдийн зарим нь шашны нэг бүлэгт, нөгөө хэсэг нь өөр нэг бүлэгт орж эхэлсэн нь санваартан болон хөрвөгчид аль алиных нь сайн сайхан бодол санаа бодит байдлаас илүү хуурмаг нь харагддаг байв; их будлиан хийгээд муу муухай бодлын дүр зураг — санваартан санваартныхаа эсрэг, түүнчлэн хөрвөгч хөрвөгчийнхөө эсрэг мэтгэлцэх нь дагалдан гарч байлаа, тийнхүү бие биенийхээ талаарх сайн сайхан санаа бодлууд, хэрэв энэ нь тэдэнд байлаа гэхэд, үгийн “сөргөлдөөн хийгээд санал зөрөлдөөнд бүхэлдээ алга болж байв.

7 Энэ үед би арвантаван настай байв. Миний эцгийн гэр бүл пресбитриений итгэлд хөрвүүлэгдээд байлаа, мөн тэднээс дөрөв нь, нэрлэвэл, миний ээж Люси; ах нар Хайрум болон Самуел Харрисон мөн миний эмэгтэй дүү Софрония тэр сүмд нэгдсэн байлаа.

8 Энэхүү их үймээний үед миний оюун буурь суурьтай бясалгал хийгээд их хүндрэлд учраад байв; хэдийгээр миний бодол санаа гүн гүнзгий хийгээд хурц байсан хэдий ч, хэдийгээр би тэдний зарим нэг цуглаануудад их төлөв тохиолдлын байдлаар оролцдог байсан ч гэсэн, би эдгээр

4г су Смит Хайрум.
д су Самуел Х.Смит.

5а Мат. 24:23.
6а су Уруу таталт.

бүх бүлгүүдээс өөрийгөө хол байлгадаг байлаа. Цаг хугацаа өнгөрөх тусам миний оюун методист урсгалд ямар нэг байдлаар татагдаж, мөн тэдэнтэй нэгдэх хүсэл ямар нэг хэмжээгээр надад бий болов; гэвч шашны янз бүрийн бүлгүүдийн дундах будлиан хийгээд сөргөлдөөн тийм их байсан нь, хүмүүс болон юмстай төдийлөн танилцаж амжаагүй миний мэт залуу хүний хувьд, хэнийх нь зөв, бас хэнийх нь буруу байсан тухайд ямар нэг тодорхой дүгнэлт хийх боломжгүй байв.

9 Миний оюун зарим үед нэн ихээр догдолж, залбирал хийгээд үймээн самуун туйлын их бөгөөд байнгын байлаа. Баптистууд болон методистуудын эсрэг хамгийн ихээр дайсагнаж, тэдний алдааг нотлохын тулд, эсвээс наанадаж л тэд буруу хэмээн хүмүүст бодогдуулахын тулд учир шалтгааны хийгээд хуурмаг дүгнэлт аль алиных нь бүх хүчийг пресбитриенчүүд ашигладаг байлаа. Нөгөө талаас, баптистууд болон методистууд хариуд нь өөрсдийн шашны номлолуудыг үнэн мэтээр сэргүүлэн тавьж мөн бусад бүгдийг эсэргүүцэхэд нэгэн адил махран зүтгэж байв.

10 Үгийн болон санаа бодлын үймээн самуунтай энэхүү дайны дунд би: Яах билээ? Эдгээр бүх бүлэглэлүүдээс хэн нь “зөв бол; эсвэл тэд бүгдээ-

рээ буруу юу? Хэрэв тэднээс аль нэг нь зөв бол, аль нь бол, тэгвэл би үүнийг яаж мэдэх вэ? хэмээн өөрөөсөө олонтаа асуудаг байлаа.

11 Шүтлэгтнүүдийн эдгээр бүлэглэлүүдийн тэмцлээр бий болсон туйлын хүнд байдал дор хөдөлмөрлөн байхдаа би нэг өдөр Иаковын захидлын нэгдүгээр бүлэг, тавдугаар шүлэг дэх: *Харин та нарын хэн нэг нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруутгалгүйгээр өгөгч Бурханаас гуйг, энэ нь түүнд өгөгдөх болно* гэснийг уншив.

12 Судрын ямар ч хэсэг энэ удаад надад тохиолдоноос илүү хүчтэйгээр хүмүүний зүрх сэтгэлд ирж байсан нь хэзээ ч үгүй бөлгөө. Энэ нь миний зүрх сэтгэлийн бодол болгонд агуу хүчтэйгээр нэвтрэн орох мэт санагдаж билээ. Хэрэв хэн нэгэн хүнд Бурханаас мэргэн ухаан хэрэгтэй байгаа бол тэр нь би мөн гэдгийг мэдсэнээр би энэ талаар дахин дахин тунгаан бодсон; учир нь би яахаа мэдэхгүй байлаа, мөн хэрэв тэр үед өөртөө байснаас илүү мэргэн ухааныг би олж авч чадаагүй бол, би хэзээ ч үүнийг мэдэхгүй байсан биз ээ; учир нь өөр өөр урсгалуудын шашны багш нар судрын яг адил хэсгүүдийг өөр өөрөөр “ойлгодог байсан нь” Библид хандан асуудлыг шийдэхэд итгэлтэй байхыг үгүй болгодог байв.

13 Нэг бол би харанхуй хийгээд төөрөгдөлд үлдэх эсвэл би, Иаковын чиглүүлснээр, Бурханаас “асуух ёстой гэдэг дүгнэлтэд урт удаан хугацааны дараа хүрэв. Хэрэв мэргэн ухаан дутсан тэдэнд тэрбээр мэргэн ухааныг, мөн чөлөөтэйгөөр өгдөг, бас буруутгадаггүйг мэдсэнээр би ч гэсэн зориглоод, “Бурханаас асуухаар” урт удаан хугацааны дараа шийдэв.

14 Ийнхүү, үүнийг Бурханаас асуухаар би нэгэнтээ шийдсэний дагуу би оролдоод үзэхээр ой уруу очив. Энэ бол нэг мянга найман зуун хорин оны хаврын нэгэн сайхан, цэлмэг өдрийн өглөө байлаа. Энэ бол би амьдралдаа ийм оролдлого хийсэн нь анхных байв, учир нь өөрийн бүхий л зовнилуудын дунд бибээр хэзээ ч чангаар “залбирч үзээгүй байлаа.

15 Очихоор өмнө нь товлосон газартаа очсоны дараа би эргэн тойрноо хараад, ганцаараа байгаагаа мэдэж, өвдөг сөгдөн суугаад зүрх сэтгэлийнхээ хүслүүдийг Бурханд өргөж эхлэв. Тэр даруй намайг бүхэлд нь эзэмдсэн ямар нэг хүчээр би баригдан, мөн би ярьж чадахгүй болтлоо хэл минь гацаж, ийм нэгэн гайхалтай нөлөөлөлд автав. Миний эргэн тойронд түнэр харан-

хуй болж, гэнэтийн устгалын хувь тавилан надад ирсэн мэтээр надад түр зуур санагдаж билээ.

16 Гэвч, намайг барьж авсан энэхүү дайсны хүчнээс өөрийгөө чөлөөлүүлэхийн тулд Бурханыг “дуудахад бүх хүчээ шавхан дайчилж мөн цөхрөлд живж, бас устгалыг урьд өмнө нь би хүмүүн биед хэзээ ч мэдэрч байгаагүй гайхмаар хүч бүхий үл үзэгдэх ертөнцийн нэгэн бодит хүчинд өөрийгөө тавьж өгөхөд бэлэн болоод байсан яг тэр мөчид—энэхүү агуу түгшүүрийн яг тэр мөчид, өөрийнхөө чанх орой дээр ⁶нарнаас илүү хурц гэрэлтэй “гэрлэн багана над уруу алгуурхан доош бууж ирэхийг би харлаа.

17 Намайг хүлсэн тэрхүү дайснаас миний бие чөлөөлөгдсөн нь удалгүй мэдэгдэв. Мөнөөх гэрэл над дээр тогтоход гялалзсан өнгө хийгээд “алдар сууг нь дүрслэхийн аргагүй ⁶хоёр Хүн миний дээр агаарт зогсож байхыг би ⁶харав. Тэдний нэг нь надтай ярьж, намайг нэрээр минь дуудан мөн нөгөөх уруугаа зааж хэлэв—*Энэ бол миний ‘Хайртай’⁹ Хүү, Түүнийг сонс!*

18 Их Эзэнээс “асуухаар ирсэн миний зорилго бол бүх урсгалуудаас аль нь зөвийг,

13a су Залбирал.

14a су Залбирал.

16a Мосе 1:20.

б Илч. 1:16.

в Үйлс 26:13.

17a су Алдар суу.

б Үйлс 7:55–56;

Кол. 3:1.

су Бурхан, Бурхан тэргүүтэн.

в су Үзэгдэл.

г Мат. 3:17; 17:5;

3 Ниф. 11:7.

д су Есүс Христ.

18a С ба Г 6:11; 46:7.

мөн алинд нь би нэгдэж болохыг мэдэх явдал байв. Тиймийн тул, удалгүй, би биеэ эзэмдэж, тийнхүү ярих чадалтай болоод, бүх урсгалуудаас аль нь зөв болохыг, (учир нь бүгдээрээ буруу гэдэг нь тэр үед миний зүрх сэтгэлд хэзээ ч бодогдоогүй байв) мөн алинд нь би нэгдэх ёстойг миний дээр гэрэл дотор зогсож байсан Хүмүүсээс асуув.

19 Тэдгээрийн алинд нь ч чи нэгдэх ёсгүй хэмээн надад хариулав, учир юун гэвэл тэдгээр нь бүгдээрээ “буруу ажээ; мөн тэдний бүхий л итгэл үнэмшил түүний мэлмийд жигшүүрт явдал бөлгөө; сүсэг бишрэл тунхаглагч тэд бүгдээрээ ялзарсныг, мөн “тэд уруулаараа надтай ⁶ойр боловч “зүрх сэтгэлээрээ надаас хол байдаг; тэд хүмүүний ‘зарлигуудыг сургаал болгон заадаг, тэд бурханлиг байдлын ⁹дүртэй боловч, түүний хүчийг үгүйсгэдэг” хэмээн надад хандсан мөнөөх Хүн хэлэв.

20 Тэрбээр намайг тэдний алинтай нь ч нэгдэхийг дахин хориглов; мөн миний бие өнөө үед бичиж үл чадах бусад олон зүйлийг тэрбээр надад хэлсэн буюу. Мөн би дахин ухаан ороход бибээр тэнгэр өөд харан нуруугаараа хэвтэж байв. Гэрэл алга болоход, би бүр тамирдсан

байлаа; гэвч удалгүй нилээд сэргэж, би гэр өөдөө явлаа. Мөн намайг пийшин налан зогсож байтал, ээж надаас юу болсныг асуув. Зүгээр ээ, бүх юм сайн — Би дажгүй ээ хэмээн би хариулав. Тэгээд би ээждээ, пресбитриений сургаал үнэн биш гэдгийг би өөртөө мэдэж авлаа хэмээн хариулав. Амьдралын маань бүр эхэн үед намайг түүний хаант улсыг эсэргүүцэгч мөн өдөгч байх тавилантайг “дайсан мэддэг байсан бололтой; тийм бус аваас харанхуйн хүчнүүд яагаад миний эсрэг нэгдэх учиртай билээ? Яагаад тэрхүү ⁶сөрөг үзэл хийгээд мөрдлөг хавчлага бараг л намайг балчир байхад миний эсрэг эхэлсэн юм бэ?

Зарим номлогчид хийгээд сүсэг бишрэлээ тунхаглагч тэд Анхны Үзэгдлийн шастирыг эсэргүүцэв — Мөрдлөг хавчлага Иосеф Смит дээр овоологдов — Тэрээр үзэгдлийн үнэн бодитойг гэрчлэв. (Шүлэг 21–26.)

21 Би энэ “үзэгдлийг харсны дараа, дээр дурдсан шашны сонирхолд нэн идэвхтэй байсан методист номлогчдын нэгэнтэй хамт байсан юм; түүнчлэн шашны сэдвээр түүнтэй ярилцахдаа, өөрийн харсан үзэгдлийн талаарх шастирыг түүнд мэдүүлэх

19a Дуул. 14.
су Урвалт—
Эртний Христийн
Сүмийн урвалт.
б Иса. 29:13–14;
Езек. 33:30–31.

в су Урвалт—
Нийтийг хамарсан
урвалт.
г Тим. 1:14;
С ба Г 45:29.
д 2 Тим. 3:5.

20a су Чөтгөр.
б 2 Ниф. 2:11;
С ба Г 58:2–4.
су Дайсан.
21a су Анхны Үзэгдэл.

нэгэн далим надад олдсон билээ. Түүний ааш авирт би нэн их гайхав; тэр миний ярьсан зүйлд зөвхөн хөнгөмсөг хандсан төдийгүй; эдүгээ үед ⁶үзэгдэл буюу ⁶илчлэлт мэтийн юмс байдаггүй, энэ мэтийн зүйлүүд төлөөлөгчдөөр дууссан, мөн тэдгээрээс аль нь ч цаашид хэзээ ч байхгүй байх болно хэмээн хэлж, харин ч бүр ихэд зэвүүцсэн байдалтай хандав.

22 Гэвч миний өгүүлж буй түүх сүсэг бишрэл тунхаглагчдын дунд миний эсрэг агуу атаа хорслыг дэвэргэж, мөн улам өсөн нэмэгдэж буй агуу ⁴мөрдлөг хавчлагын шалтгаан болж байсныг би төдөлгүй ойлгов; мөн хэдийгээр би зөвхөн арван дөрөв тавтай ⁶балчир хөвгүүн байсан ч, өндөр хэргэм зэрэгтнүүд, амьдралд байр сууриа олоогүй миний энэхүү нөхцөл байдлыг олзуурхан шүүрч, олон нийтийн санаа бодлыг миний эсрэг хандуулж байсныг би олж мэдсэн билээ; мөн энэ нь бүх бүлгүүдэд адилхан байсан бөгөөд бүгд миний эсрэг мөрдлөг хавчлагад нэгдсэн билээ.

23 Өдөр тутмын хөдөлмөрөөрөө тарчигхан амьдралаа залгуулж яваа, нэрд гараагүй дөнгөж арван дөрөв гарч яваа хөвгүүн тэр үеийн хамгийн нэр хүнд бүхий шашны алдар нэртэй хүмүүсийн анхаарлыг татаж, хамгийн

харгис мөрдлөг хавчлага хийгээд доромжлолын санааг тэнд төрүүлсэн нь туйлын хачирхалтай санагдан, түүнээс хойш энэ тухай илүү ихийг бодох болов. Гэвч хачирхалтай ч бай, үгүй ч бай, энэ нь ихэнхдээ миний уй гашуугийн шалтгаан болсон юм.

24 Хэдий тийм ч, энэ бол үнэндээ би үзэгдэл харсан явдал байв. Үүнээс хойш би өөрийгөө гэрэл харж, дуу хоолой сонссон, үзэгдэл харсан хэмээн Агрийп хааны өмнө хэлсний улмаас ⁴хамгаалж асан ⁶Паултай адилаа бодох болов; гэвч цөөн хэдээс бусад нь түүнд итгээгүй юм; зарим нь түүнийг шударга бус хэмээн хэлж, бусад нь түүнийг ууртай байсан хэмээн хэлж байв, мөн түүнийг дооглон бас доромжилж байсан билээ. Гэвч энэ бүхэн түүний үзэгдлийн үнэн бодитойг устгаж чадаагүй юм. Тэрээр үзэгдэл харсан, үүнийгээ тэр мэдэж байсан бөгөөд тэнгэрийн доорх бүх мөрдлөг хавчлага үүнийг өөрчилж чадахгүй юм; хэдийгээр тэд түүнийг үхтэл нь мөрдөн хавчсан ч тэрээр гэрэл харж мөн түүнтэй ярьсан дуу хоолой сонссоноо эцсийнхээ амьсгалыг хураах хүртэл тэрээр мэдэж байсан бөгөөд бүх дэлхий түүнийг өөрөөр бодуулж мөн өөрөөр итгүүлж чадаагүй билээ.

25 Би ч мөн түүнтэй адил

21б су Үзэгдэл.
в су Илчлэлт.
22а Иаков 5:10–11.

су Хавчих,
Хавчлага.
б1 Сам. 16:7;

Алма 37:35.
24а Үйлс 26:1–32.
б су Паул.

байв. Үнэндээ би гэрэл харсан бөгөөд тэр гэрлийн дунд хоёр “Хүнийг харсан, бас тэд үнэн бодитойгоор надтай ярилцсан билээ; энэ нь үнэн хэдий ч, намайг үзэгдэл харсан хэмээн хэлсний төлөө мөрдөн хавчиж, мөн үзэн ядаж байсан юм; мөн тэгж хэлсний учир тэд намайг мөрдөн хавчиж, намайг доромжилж, миний эсрэг хуурамчаар янз бүрийн хилэнцтийг ярьж байсан ч гэсэн, би зүрх сэтгэлдээ: Үнэнийг хэлсний төлөө яагаад намайг хавчиж байгаа юм бэ? Үнэндээ би үзэгдэл харсан шүү дээ; Бурханы эсрэг зогсож чадах хэн юм бэ би, яагаад үнэхээр харсан зүйлээ үгүйсгэхийг дэлхий надаас хүснэ вэ? Учир нь би үзэгдэл харсан; би үүнийг мэдэх бөгөөд Бурхан ч үүнийг мэднэ гэдгийг мэднэ, би үүнийг ⁶үгүйсгэж чадахгүй, мөн үүнийг хийж зүрхлэх нь үгүй; ингэснээр ядаж л Бурханыг гомдоох бөгөөд буруутгал дор ирнэ гэдгийг би мэдэж байсан хэмээн хэлэхэд хөтлөгдсөн билээ.

26 Тэдний аль нэгэнд нэгдэх нь миний үүрэг биш, харин цаашдын удирдамж авах хүртлээ энэ хэвээрээ үлдэх, ингэснээр шашны бүлэглэлүүдийн хүрээний санаа зовж буй зүйлд би одоо сэтгэл хангалуун байх болов. Мэргэн ухаанаар дутсан хэн ч гэсэн Бурханаас асууж мөн

олж авах бөгөөд буруутгагдах нь үгүй гэсэн Иаковын “гэрчлэл үнэн болохыг мэдэж авсан юм.

Моронай Иосеф Смит дээр хүрч ирэв—Иосефын нэр бүх үндэстний дунд сайн болон муугаар мэдэгдэх болно—Мормоны Ном хийгээд ирж буй Их Эзэний шүүлтийн тухай Моронай түүнд ярьж мөн олон судраас иш татав—Алтан ялтсуудыг нуусан газар илчлэгдэв—Моронай Бошиглогчид зааварчлахаа үргэлжлүүлэв. (Шүлэг 27–54.)

27 Би мянга найман зуун хорин гурван оны есдүгээр сарын хорин нэгэн хүртэл ердийн ажлаа хийж, үзэгдэл харсан гэдгээ баталсаар байсан учраас шүтлэгтэй болон шүтлэггүй янз бүрийн хүмүүсийн хүнд хэцүү мөрдлөг хавчлагын гарт байнга зовж байлаа.

28 Намайг үзэгдэл харснаас хойш мянга найман зуун хорин гурван он хүртэлх хэсэг хугацаанд бага залуу байх үед тэр үеийн шашны бүлгүүдийн алинд нь ч нэгдэхийг надад хориглосон байв, мөн найз нөхөд минь байж, элэгсэг хандаж, хэрэв хууртагдсан гэж үзэж байсан бол, намайг буцаан авахаар засаж залруулах учиртай хүмүүс намайг мөрдөн хавчиж байсны улмаас би янз бүрийн “уруу таталтанд орж байв; мөн янз бүрийн хүмүүстэй

хутгалдаж, би удаа дараа олон мунхаг алдаа гарган, залуу насны сул тал хийгээд хүмүүний төрөлхийн жижиг сажиг сул тал илрэн гарч, Бурханы мэлмийд нүгэлт олон янзын уруу таталт уруу намайг хөтөлснийг хэлэхэд ч харуусалтай байна. Ийнхүү гэмшиж байгааг минь, намайг аливаа их, эсвээс хор хөнөөлтэй нүглүүдэд гэмтэй хэмээн хэн ч бодох хэрэггүй. Иймийг үйлдэх санаа миний уг мөн чанарт хэзээ ч байгаагүй. Гэвч хөнгөмсөг гоомойд, түүнчлэн би ийм байсанчлан, Бурханаас ^бдуудагдсан хүнд байвал зохих шинж чанартай үл нийцэх, наргианч гэхчлэн, нийгмийн иймэрхүү бүлэгтэй зарим үед холбоо сүлбээтэй байсанд би буруутай байлаа. Гэвч миний залуу насыг эргэн санадаг, түүнчлэн миний төрөлхийн хөгжүүн баяр хөөртэй зан чанарыг мэддэг хүнд энэ нь их хачин гажууд санагдахгүй биз ээ.

29 Эдгээр зүйлүүдийн улмаас, сул тал хийгээд төгс бусынхаа улмаас би буруутгадаг учиртай хэмээн олонтаа боддог байлаа; дээр дурдсан есдүгээр сарын хорин нэгний орой, тэр шөнө унтахаар хэвтсэний дараа, миний бүх нүглүүд хийгээд тэнэглэлүүдийг өршөөнө үү хэмээн, мөн тэрчлэн өөрийн байдал хийгээд түүний өмнө хэрхэн зогсож

байгаагаа мэдэхийн тулд би Бүхнийг Чадагч Бурханд хандсан “залбирал мөн даруухан залбиралд өөрийгөө зориулсан бөлгөө; учир нь, өмнө нь би нэгийг хүлээн авсны адилаар, бурханлиг тунхаглал хүлээж авна гэдэгт би бүрэн дүүрэн итгэлтэй байв.

30 Тийнхүү би Бурханыг дуудах зуур би өрөөнд маань тэр өрөөг үд дундынхаас илүү гэрэлтэй мэт болтол үргэлжлэн нэмэгдэх нэгэн гэрэл үзэгдэхийг олж мэдэхэд, нэгэн “хүмүүн бие тэр даруй миний орны дэргэд, агаарт тогтож байгаагаар үзэгдэв, учир нь түүний хөл шаланд хүрэхгүй байлаа.

31 Тэрбээр туйлын тансаг цав цагаан элбэг орхимжтой байв. Энэ нь миний урьд өмнө нь харсан газар дэлхийн бүхнээс “үлэмж цагаан байв; бас газар дэлхийн нэгээхэн ч зүйл ийм үлэмжийн цагаан мөн туяаран харагдахаар болгогдож чадна гэдэгт би итгэдэггүй. Түүний гар нь, мөн түүнчлэн бугуйнаас бяцхан дээгүүр шуу хүртлээ нүцгэн байв; түүнчлэн үүний нэгэн адил, түүний хөл нь, мөн шагайнаасаа бяцхан дээгүүр шилбэ хүртлээ нүцгэн байлаа. Түүний толгой мөн хүзүү нь түүнчлэн ил байв. Би ил цухуйж буй түүний цээжийг хараад тэрбээр энэ орхимж-

28б су Дуудах, Бурханаас дуудагдах, Дуудлага.

29а су Залбирал.
30а су Тэнгэр элчүүд;
Моронай,
Мормоны хүү.

31а Үйлс 10:30;
1 Ниф. 8:5;
3 Ниф. 11:8.

ноос өөр хувцас өмсөөгүйг би мэдэв.

32 Зөвхөн түүний орхимж л үлэмж цагаан байсан төдийгүй, бас түүний бүхий л бие нь үгээр дүрслэхийн аргагүй “туяаран, мөн түүний дүр төрх үнэнхүү” цахилгаан мэт байв. Өрөө үлэмж гэрэлтэй байсан хэдий ч, тэр хүмүүний эргэн тойрон дахь шиг тийм хурц байсангүй. Би түүнийг анх хармагцаа “айв; гэвч хоромхон зуур тэр айдас намайг орхилоо.

33 Тэрээр намайг “нэрээр минь дуудаад, мөн надад хандан тэр Бурханы дэргэдээс надад илгээгдсэн элч гэдгийг, мөн түүний нэр Моронай гэдгийг, надад зориулсан хийх нэгэн ажил Бурханд бий гэдгийг, мөн миний нэр бүх үндэстэн, ястан болон хэлтнүүдийн дунд сайнаар бас муугаар дурсагдаж, өөрөөр хэлбэл бүх хүмүүний дунд сайн болон муу аль алинаар нь яригдах болно гэдгийг хэлэв.

34 “Алтан ялтсууд дээр бичиглэгдсэн, энэ эх газрын эртний оршин суугчдын тухай, мөн тэд хаанаас үүсэж бий болсон эх сурвалжийн шастирыг агуулсан нэгэн” ном хадгалагдсаныг тэрээр

хэлэв. Түүнчлэн Аврагчаар эртний оршин суугчдад хүргэгдсэн үүрдийн Сайн мэдээний “бүрэн байдал үүнд агуулагдсаныг тэр хэлэв;

35 Түүнчлэн, мөнгөн хүрээнд суулгагдсан хоёр чулуу — мөн эдгээр чулуунууд “Урим ба Туммим гэгчийг бүрдүүлдэг” цээжний хуягтай холбогдож, ялтсуудтай хамт хадгалагдан буй; мөн эртний болон хуучин цагт эдгээр чулуунуудыг эзэмшин мөн хэрэглэсэн нь “үзмэрчид” гэгддэг байжээ; мөн Бурхан тэдгээрийг уг номыг орчуулах зорилгын тулд бэлтгэснийг буюу.

36 Эдгээр зүйлүүдийг надад ярьсныхаа дараа, тэрээр “Хуучин Гэрээний бошиглолдуудаас иш татаж эхлэв. Тэрээр эхлээд “Малахийн гуравдугаар бүлгийн хэсгийг иш татав; мөн тэрээр тэрчлэн уг бошиглолын дөрөвдүгээр буюу сүүлчийн бүлгийг бидний Библид байдаг тэрхүү хэлбэрээс бага зэрэг өөрөөр иш татлаа. Бидний номуудад байдаг нэгдүгээр шүлгийн ишлэлийн оронд тэрээр үүнийг иш татав:

37 Учрыг болгоогтун, зуух мэт “шатах тэрхүү” өдөр ирэх бөл-

32а 3 Ниф. 19:25.

су Алдар суу.

б Ег. 34:29–35;

Хил. 5:36;

С ба Г 110:3.

в Ег. 3:6;

Ифер 3:6–8, 19.

33а Ег. 33:12, 17;

Иса. 45:3–4.

34а су Алтан ялтсууд.

б су Мормоны Ном.

в су Сайн мэдээний сэргээлт.

35а Ег. 28:30.

су Урим ба Туммим.

б Лев. 8:8.

су Цээжний хуяг.

в су Үзмэрч.

36а су Хуучин Гэрээ.

б су Малахи.

37а 3 Ниф. 25:1–6;

С ба Г 64:23–24.

су Дэлхий—

Дэлхийн

цэвэршилт;

Дэлхий—Дэлхийн

төгсгөл.

б су Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт.

гөө, мөн бүх бардамнагчид, тийм ээ, мөн ёс бусаар үйлдэгч тэд бүгд ^аталбайд хаягдсан сүрэл мэт шатах болно; учир нь тэднийг шатаахаар ирэх тэд, тэднийг үндсийг ч мөн мөчрийг ч үлдээх нь үгүй хэмээн Түмний Их Эзэн айлдах ажгуу.

38 Мөн дахин, тавдугаар шүлгийг ийн иш татав: Болгоогтун, Их Эзэний агуу хийгээд аймшигт өдөр ирэхийн өмнө, бошиглогч ^аЕлиагийн гараар ^бсанваарыг би та нарт илчлэх болно.

39 Тэрбээр тэрчлэн дараачийн шүлгийг өөр байдлаар иш татав: Мөн тэрээр эцгүүдэд нь хийсэн ^аамлалтуудыг хүүхдүүдийнх нь зүрх сэтгэлд суулгах болно, мөн хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд уруугаа ^бэргэх болно. Хэрэв энэ нь ийм биш байх аваас, түүний ирэлтээр бүх дэлхий бүрмөсөн устгагдах болно.

40 Эдгээрээс гадна, тэрээр Исаиагийн долдугаар бүлгийг иш татан, энэ нь гүйцэлдэхийн даваан дээр буй хэмээн хэлэв. Тэрээр тэрчлэн Үйлсийн гуравдугаар бүлэг, хорин хоёр болон хорин гуравдугаар шүлгүүдийг бидний Шинэ Гэрээнд байдагтай яг адилаар иш татлаа. Тэрхүү ^абошиглогч нь Христ байсныг, харин ^бтүүний дуу хоолойг сонсдоггүй тэд хүмүү-

сийн дундаас ^бтусгаарлагдах” тэрхүү өдөр хараахан ирээгүй хэдий ч, удахгүй ирэх болно хэмээн тэрбээр хэлэв.

41 Тэрээр түүнчлэн “Иоелын хоёрдугаар бүлгийг, хорин наймдугаар шүлгээс сүүлчийнхийг хүртэл иш татав. Энэ нь хараахан гүйцэлдээгүй ч гэсэн, удахгүй тохиох болно хэмээн тэрээр бас хэлэв. Мөн ^бхарийнханы бүрэн байдал удахгүй тохиох болно хэмээн тэрээр цааш нь өгүүлэв. Тэрбээр судрын өөр олон хэсгүүдийг иш татан, мөн энд дурдаж үл болох олон тайлбарыг өгүүлэв.

42 Түүнчлэн, тэдгээрийг авах цаг хараахан бүрдээгүй байсан учир — би түүний ярьсан тэдгээр ялтсуудыг аваад, би нэг ч хүнд үзүүлэх ёсгүй байв; мөн үүний нэгэн адил Урим ба Туммимтай цээжний хуягийг ч, үүнийг үзүүлэхийг зарлигласан хүмүүст л болой; хэрэв эс тэгвээс би устгагдах ёстойг тэрээр надад хэлэв. Уг ялтсуудын тухай түүнийг надтай ярилцаж байх зуур миний “оюунд үзэгдэл нээгдэн би уг ялтсууд хаана хадгалагдсан байгааг, мөн би тэнд очихдоо уг газрыг дахин танихуйц маш илэрхий бас тодорхойгоор харж чадав.

37в Нахум 1:8–10;
1 Ниф. 22:15, 23;
2 Ниф. 26:4–6;
С ба Г 29:9.
38а С ба Г 27:9;
110:13–16.
су Елиа.

б су Санваарын
түлхүүрүүд;
Санваартан.
39а Гал. 3:8, 19.
б су Удмын бичиг;
Нас барагсдын
аврал.

40а Дэд хууль 18:15–19.
б 3 Ниф. 20:23; 21:20.
41а Үйлс 2:16–21.
б Ром 11:11–25;
С ба Г 88:84.
су Харийнхан.
42а су Оюун.

43 Энэхүү харилцааны дараа, өрөөн дэх гэрэл надад ярьж байсан түүний биеийн эргэн тойронд хуралдахыг би харж, мөн энэ нь түүний дэргэд биш бол, өрөө дахин харанхуй болтол үргэлжлэв, би даруй харвал, шууд тэнгэр дээш одох суваг мэт, мөн тэрээр үзэгдэхгүй болтлоо дээшлэн одов, мөн өрөө энэхүү тэнгэрлэг гэрэл үзэгдэхээс өмнө байсан янзаараа орхигдсон байв.

44 Би болсон явдлын өвөрмөц байдлыг бодон хэвтэв, мөн энэ ер бусын элчээр надад хэлэгдсэн зүйлд үлэмж ихээр гайхашран байв; намайг ийнхүү “бодлогошрон байх зуур, өрөө маань дахин гэрэлтэж эхлэхийг би гэнэтхэн ажиглав, мөн агшин зуур мэт, мөнөөх тэнгэрлэг элч дахин орны минь дэргэд байв.

45 Тэрээр эхэлж, мөн өөрийн эхний айлчлалын үед ярьсантайгаа адил зүйлүүдийг өчүүхэн ч өөрчлөлтгүйгээр дахин өгүүлэв, үүнийг үйлдээд, өлсгөлөн, илд мэс мөн өвчин тахлаар ирэх агуу сүйрэл болох тэр, газар дэлхий дээр ирж буй агуу шүүлтүүдийн тухай тэрээр надад мэдүүлэв; мөн эдгээр хатуу шүүлтүүд энэ үеийнхэнд дэлхийд ирэх ажээ. Эдгээр зүйлүүдийг өгүүлээд, тэрээр дахин урьдын адил дээшлэн одов.

46 Энэ үед, миний оюунд

маш гүнзгий сэтгэгдэл төрснөөс нойр минь хулжин, мөн харсан болон сонссон түүндээ, гайхал бахдалдаа эзэмдүүлэн хэвтэж байв. Гэвч би мөнөөх элч орны минь дэргэд байхыг дахин хараад, мөн урьдын адил зүйлүүдийг надад тэрээр давтан өгүүлэхийг сонсоод би хичнээн их гайхсан гээч; мөн надад сануулга болгон нэмж (эцгийн минь гэр бүлийн ядуу тарчиг амьдралын үр дагавар болж) ялтсуудыг баяжих зорилгын тулд эзэмшүүлэхээр “Сатан намайг уруу татахыг хичээх болно гэдгийг хэлэв. Үүнд тэрээр надад хориг тавин, бибээр уг ялтсуудыг авахдаа Бурханыг алдаршуулахаас өөр бусад ямар ч сонирхлоос татгалзах ёстой хэмээв, мөн түүний хаант улсыг байгуулахаас өөр ямар нэгэн шалтгааны нөлөөлөлд автагдах ёсгүйг; өөрөөр бол бибээр тэдгээрийг авч чадахгүйг хэлэв.

47 Энэ гурав дахь айлчлалын дараа, тэрээр дахин урьдын адил тэнгэрт дээшлэн одов, мөн би дөнгөж тохиолдсон зүйлийн хачныг гайхан тунгаахаар дахин ганцаараа хоцорсон байв; тэгээд тэр тэнгэрлэг элч намайг гурав дахь удаагаа орхин дээшилсний дараа бараг тэр даруй, азарган тахиа донгодов, мөн би өдөр ойртож байгааг, иймээс бидний уулзалт бүхэл шөнийг эзэлснийг мэдэв.

48 Би үүний дараа удалгүй орноосоо босч, мөн ердийн байдлаараа өдрийн зайлшгүй хийх ажилдаа гарлаа; гэвч ердийнхөөрөө ажиллахыг хичээх зуур, хүч минь шавхагдсанаас, ажиллах боломжгүй байгаага мэдэв. Надтай хамт ажиллаж байсан миний эцэг, миний жирийн бус байдлыг ажиглаад, мөн гэртээ харь гэж надад хэлэв. Би байшин уруугаа очих санаатай явж эхлэв; гэвч бидний байсан талбайгаас гарахаар хашаа давах гэж хичээх үед, миний бүх хүч шавхагдан, би арчаагүйгээр газарт унаж, мөн хэсэг хугацаанд юу ч мэдэхгүй муужирсан байлаа.

49 Юун түрүүнд миний санаж чадсан зүйл нь надад ярьж, намайг нэрээр минь дуудах дуу байлаа. Би дээш харж, мөн мөнөөх элч миний толгойн тус газар өмнөх янзаараа гэрлээр хүрээлүүлэн зогсож байхыг харав. Тэгээд тэрээр урьд шөнө надад ярьсан зүйлээ бүгдийг надад дахин ярьж, мөн “эцэгтээ очиж бас түүнд өөрийн хүлээн авсан тэр үзэгдэл мөн зарлигуудын тухай хэлэхийг надад зарлиг болгов.

50 Би дуулгавартай дагалаа; би талбайд аавдаа буцаж очоод, мөн бүхий л болсон явдлыг түүнд давтан хэлэв. Энэ нь Бурханаас байсан хэмээн тэрээр надад хариулж, мөн явж уг элчээр зарлиг

болгогдсоныг хий гэж надад хэлэв. Би талбайг орхин, мөнхүү элч уг ялтсууд хадгалагдан байгааг надад хэлсэн тэр газар уруу явлаа; мөн үүний талаар би үзэгдэлд тодорхой харсан учраас, би тэнд очсон даруйдаа уг газрыг танив.

51 Нью-Йоркийн Онтарио гүнлэгийн Манчестер тосгоны ойролцоо, орчин тойрондоо хамгийн өндөр болох нилээд томоохон “гүвээ байдаг. Энэ гүвээний баруун талд, оройгоос нь холгүй, томоохон чулууны дор, чулуун хайрцганд хадгалагдсан ялтсууд байлаа. Энэ чулуу нь төв рүүгээ дээш товойсон зузаан, харин захаараа нимгэвтэр учир төв хэсэг нь газраас дээш харагдахаар, харин эргэн тойрон бүх захын хэсэг нь шороонд булагдсан байлаа.

52 Шороог нь зайлуулаад, би хөшүүрэг олж аваад, түүнийг би чулууны зах доогуур ивж, мөн бага зэрэг хүчлээд үүнийг дээш өргөв. Би дотогш харж, мөн элчийн дурдсан уг “ялтсуудыг, басхүү “Урим ба Туммим мөн “цээжний хуягийг үнэхээр харав. Тэдгээр зүйлс дотор нь байсан уг хайрцаг нь чулуунуудыг ямар нэг цементээр нэгтгэж хийгдсэн байлаа. Уг хайрцагны ёроолд, хоёр чулууг хэрээс болгон хөндөлдүүлэн тавьж, мөн эдгээр чулуунууд дээр ялтсууд болон

49а су Ахмад Иосеф Смит.
51а су Кумора гүвээ.

52а Морм. 6:6.
су Алтан ялтсууд.
б су Урим ба

Туммим.
в су Цээжний хуяг.

тэдэнтэй хамт бусад зүйлүүд тавигдсан байв.

53 Би тэдгээрийг гаргахаар завдсан боловч, элчээр хориглогдож, мөн тэдгээрийг авчрах цаг нь хараахан болоогүй, тэр цагаас дөрвөн жилийг улиртал энэ нь тохиохгүй хэмээн дахин сануулагдав; гэвч би тэр цагаас яг нэг жилийн дараа уг газарт ирвэл зохино гэдгийг, мөн тэр тэнд надтай уулзана гэдгийг, мөн би уг ялтсуудыг авах цагийг иртэл тэрчлэн үйлдэх ёстойг тэрээр надад хэлсэн бөлгөө.

54 Тэрчлэн надад зарлигласны дагуу, би жил бүрийн эцэст очиж, мөн тухай бүрд би өнөөх элчтэй тэнд уулзаж, мөн Их Эзэн юу хийх гэж буй тухай, мөн түүний “хаант улс хэрхэн бас ямархуу маягаар эцсийн өдрүүдэд удирдагдахыг заавар ба мэдлэг болгон бидний ярилцлага бүрд түүнээс хүлээн авч байлаа.

Иосеф Смит Эмма Хейлтэй гэрлэв—Тэрээр алтан ялтсуудыг Моронайгаас хүлээн авч мөн зарим хэсгийг нь орчуулав—Мартин Харрис хэсгүүдийг болон орчуулгыг Профессор Антонд үзүүлэхэд, тэрээр “Би лацдагдсан номыг уншиж чадахгүй юм байна” хэмээн хэлжээ (Шүлэг 55—65).

55 Миний эцгийн дэлхийн нөхцөл байдлууд туйлын хязгаарлагдмал байсан уч-

раас, өдрийн хөлсний ажил олж хийх, эсвээс бидэнд азтай боломж олдсоноор бид өөрсдийнхөө гараар хөдөлмөрлөх зайлшгүй шаардлагатай байлаа. Заримдаа бид гэртээ, заримдаа гэрээсээ хол байдаг байв, мөн урт удаан хөдөлмөрийн улмаас бид ая тухтай байдалд байх боломжгүй байв.

56 1823 онд миний том ах “Алвин нас барснаар эцгийн минь гэр бүлд их зовлон зүдгүүр учрав. 1825 оны аравдугаар сард Нью-Йорк муж улсын Ченанго гүнлэгт амьдарч асан Жозиа Стоал нэртэй нэгэн настай эр намайг хөлсний ажилд авлаа. Пенн-сильвани муж улсын Хармонид испаничуудын нээсэн мөнгөний уурхайн талаар тэрбээр ямар нэг зүйл сонсон байв; тэгээд намайг өөртөө хөлслөхөөс өмнө хэрэв боломжтой бол уурхай олж нээхийн тулд газар ухаж байжээ. Намайг түүнтэй хамт амьдрахаар очсоны дараа тэрээр үлдсэн ажилчдынхаа хамт мөнгөний уурхай ухахаар намайг авч яван, би тэнд бараг нэг сар ажил хэрэгтээ амжилт эс гарган ажилласаар байлаа, тэгээд эцэст нь үүнийг ухахаа зогсоохыг мөнөөх настай эрд ятган итгүүлж чадав. Бибээр мөнгө ухагч байсан тухай нэн өргөн тархсан түүх эндээс үүдэлтэй юм.

57 Би ийнхүү ажилтай байсан үеийн туршид, тэр газрын ноён Исаак Хейлтэй хамт нэг байранд суухаар хуваарилагдсан байлаа; тэнд би эхнэрээ (түүний охин), “Эмма Хейлийг анх удаа олж харсан нь энэ бөлгөө. 1827 оны нэгдүгээр сарын 18-нд бибээр ноён Стоалын үйлчлэлд ажилтай байх үед бид гэрлэв.

58 Би үзэгдэл харсан тухайгаа шаргуугаар нотолж байсны улмаас, “мөрдлөг хавчлага намайг дагасаар л байв, мөн миний эхнэрийн гэр бүл бидний гэрлэснийг туйлын их эсэргүүцэж байлаа. Тиймийн тул, би түүнийг өөр газар уруу авч явах зайлшгүй шаардлагатай болов, тиймээс, бид тэндээс явж, тэгээд Нью-Йоркийн Ченанго гүнлэгийн Өмнөд Бейнбрижид Сквайре Тарбиллын гэрт гэрлэв. Би гэрлэмэгцээ ноён Стоалынхыг орхиж, тэгээд эцгийнхээ гэр бүлд очин, тэр улиралд түүнтэй хамт газар тариаланд ажиллав.

59 Эцэст нь уг ялтсуудыг, Урим ба Туммим, мөн цээжний хуягийг авах цаг боллоо. Нэг мянга найман зуун хорин долоон оны есдүгээр сарын хорин хоёрны өдөр, ердийн адил тэдгээрийн хадгалагдсан газарт жилийн эцсээр ирэхэд, урьд уулзсан тэнгэрлэг элч: Би тэдгээрийн төлөө хариуцлага хүлээх ёстой; хэрэв

би тэдгээрийг хайнгаас, эсвээс өөрөө “хайхрамжгүйгээс алдвал, би тусгаарлагдах ёстой болно; гэвч хэрэв би өөрийн бүх хүчээр тэдгээрийг хадгалахыг ⁶чармайх аваас, уг элч, тэдгээрийг хүсэх хүртэл, тэдгээр нь хамгаалагдах болно хэмээх энэ үүргийг хүлээлгэхийн хамт тэдгээрийг надад гардуулав.

60 Удалгүй би яагаад тэдгээрийг аюулгүй байдалд хадгалах тийм хатуу чанд үүрэг хүлээн авч, мөн миний гарт даалгагдсаныг хийж гүйцэтгэсний дараа, тэрээр тэдгээрийг хүсэх болно хэмээн уг элч юуны учир хэлсний шалтгааныг олж мэдсэн бөлгөө. Тэдгээр нь надад байгаа гэдэг нь мэдэгдмэгц тэдгээрийг надаас авахын тулд хамгийн идэвхтэй оролдлогууд хэрэглэгдэж байлаа. Уг зорилгын тулд хүний санаанд орж болох бүхий л заль мэх сэдэгдэн хэрэглэгдэж байлаа. Мөрдлөг хавчлага урьдынхаасаа улам харгис бас хатуу болж, мөн бүлэг хүмүүс, хэрэв боломж олдвол тэдгээрийг надаас авахаар үргэлж бэлэн байдалд байв. Гэвч Бурханы мэргэн ухаанаар, тэдгээр нь миний гарт аюулгүй байдалд, гарт минь даалгасан тэдгээрийг биелүүлтэл үлдсэн юм. Тохиролцсоны дагуу, уг элч тэдгээрийг хүсэхэд би түүнд тэдгээрийг гардуулж өгсөн билээ; мөн

57a су Смит, Эмма

Хэйл.

58a су Хавчих,

Хавчлага.

59a ИС—Т 1:42.

б су Судрууд—

Хадгалагдсан байх судрууд.

тэрээр тэдгээрийг өөрийн мэдэлд энэ өдөр болох нэг мянга найман зуун гучин найман оны тавдугаар сарын хоёр дахь өдрийг хүртэл байлгаж буй болой.

61 Гэсэн хэдий ч, сэтгэл хөөрөл үргэлжилсэн хэвээр байж, мөн миний эцгийн гэр бүлийн болон миний талаар мянга түмэн худал хуурмаг хар хэл ам, цуу үг үргэлж гарсаар байв. Хэрэв бибээр тэдгээрийн мянганы нэг хувийг өгүүлэх аваас, энэ нь олон ботийг дүүргэх биз ээ. Гэсэн хэдий ч мөрдлөг хавчлага намайг эхнэрийнхээ хамт Манчестерыг орхин Пеннсильвани муж улсын Сасквиеханна гүнлэг уруу явахаас аргагүйд хүргэсэн тийм тэсэхүйеэ бэрх болов. Эхлэхээр бэлтгэж байсан тэр үед — нэн ядуу байсны улмаас, түүнчлэн бид өөрөөр байх боломжгүй тийм хүнд бэрх мөрдлөг хавчлага бидэн дээр ирсэн тэр үед — бидний зовлон зүдгүүрүүдийн дунд бидэн дээр ирж, аялалд маань бидэнд туслахын тулд надад тавин доллар өгсөн, найз, “Мартин Харрис хэмээх нэртэй нэгэн хүнтэй бид танилцав. Ноён Харрис Нью-Йорк муж улсын Вайне гүнлэгийн Палмира хотхоны оршин суугч, түүнчлэн хүндэтгэл хүлээсэн фермийн эзэн байв.

62 Цагаа олсон энэ туслам-

жаар би Пеннсильвани дахь хүрэх газартаа очих боломжтой болов, мөн бибээр тэнд очмогцоо ялтсуудын үсгүүдийг хуулбарлаж эхлэв. Тэдгээрээс нилээд олныг нь хуулбарлаж, мөн “Урим ба Тумми”-ыг ашиглан би тэдгээрийн заримыг нь эхнэрийнхээ эцгийн гэрт хүрч ирсэн арванхоёрдугаар сар, мөн хоёрдугаар сарын хооронд би орчуулсан бөлгөө.

63 Энэ хоёрдугаар сард нэг удаа дээр дурдсан ноён Мартин Харрис манайд ирж, ялтсуудаас миний хуулбарлаж авсан үсгүүдийг авч Нью-Йорк хот уруу явав. Түүнд болон үсэгнүүдэд юу тохиолдсон тухайд, тэрээр эргэж ирснийхээ дараа тэдгээрийн талаар надад өгүүлэв, нөхцөл байдлын талаарх түүний өөрийнх нь мэдээллийг би иш татъя, энэ нь дараах зүйл байв:

64 “Би Нью-Йорк хотод очиж, бичиг үсгийн мэдлэгээрээ алдаршсан, боловсон эр профессор Чарльз Антонд орчуулагдсан бичгүүдийг тэдгээрийн орчуулгын хамт үзүүлэв. Орчуулга нь египет хэлнээс орчуулагдсаныг, өмнө нь түүний үзсэн аль ч орчуулгаас илүү зөв байсныг профессор Антон нотлов. Тэгээд би орчуулагдаагүй байсныг нь түүнд үзүүлэхэд тэрбээр өгүүлэн, тэдгээр нь египет, халдеи,

ассири болон араб хэлээр байна хэмээн хэллээ. Тэдгээр нь жинхэнэ бичиг байсан хийгээд тэдгээрээс тийнхүү орчуулагдсаных нь орчуулга тэрчлэн зөв байсныг Палмирын хүмүүст нотлон тэрээр надад гэрчилгээ өгөв. Би гэрчилгээг аваад, үүнийг халаасандаа хийж, тэднийхээс гарах гэтэл ноён Антон намайг гэдрэг дуудаж, тэр залуу хүн алтан ялтсууд байсан газраас тэдгээрийг хэрхэн олж авсныг надаас асуув. Бурханы нэгэн тэнгэр элч үүнийг түүнд илчилснийг би хариуллаа.

65 Тэрбээр дараа нь нөгөөх гэрчилгээг чинь үзье хэмээн надад хэлэв. Тэр дагуу би үүнийг халааснаасаа гаргаж түүнд өгөхөд тэрээр үүнийг аваад, жижиг хэсгүүд болгон урж хаяад, эдүгээ тохинуулагч “тэнгэр элчүүд гэгч юм байхгүй, хэрэв би ялтсуудыг түүнд авчирч өгөх аваас тэрээр тэдгээрийг орчуулж болох юм хэмээн хэлэв. Ялтсуудын нэг хэсэг нь ⁶лацдагдсан бөгөөд мөн тэдгээрийг авч явахыг надад хориглосныг би түүнд мэдээллээ. “Би лацдагдсан номыг уншиж чадахгүй” хэмээн тэрбээр хариулав. Би түүнийг орхин мөн бичгүүд хийгээд орчуулга аль алиных нь талаар профессор Антоны хэлснийг зөвшөөрсөн доктор Митчел уруу очлоо.

••••

Оливер Каудери Мормоны Номыг орчуулахад бичээчээр үйлчлэв— Иосеф Оливер хоёр Иохан Баптистаас Аароны санваар хүлээн авав—Тэд баптисм хүртэж, томилогдож, мөн бошиглолын сүнс хүлээн авав. (Шүлэг 66–75.)

66 1829 оны дөрөвдүгээр сарын 5 дахь өдөр “Оливер Каудери манай гэрт ирэв, энэ үеийг хүртэл би түүнийг огт хараагүй байлаа. Хүүхдүүдээ явуулдаг байсан хүмүүсийн нэг болох миний аавын амьдардаг газрын сургуульд тэрээр багшилдаг бөгөөд тэрээр түүний гэрт хэсэг хугацаанд суухаар очиж, тэгээд тэнд байхад нь ялтсуудыг би хүлээн авсан нөхцөл байдлуудын талаар миний эцгийн гэр бүл түүнд ярьж, мөн тэр дагуу тэрээр надаас асуухаар ирлээ хэмээн тэрээр надад яриу.

67 Ноён Каудерийг ирснээс хойш хоёр өдрийн дараа (дөрөвдүгээр сарын 7-н байв) би Мормоны Номыг орчуулж эхлэн, мөн тэрээр надад зориулан бичиж эхлэв.

••••

68 Биднийг орчуулгын ажлаа үргэлжлүүлж байтал, дараагийн сард нь (1829 оны тавдугаар сар) дээр дурдсан ялтсуудын орчуулганд бидэнд тааралдсан нүглүүдийн

65a су Тэнгэр элчүүд.
б Иса. 29:11–12;

2 Ниф. 27:10;
Ифер 4:4–7.

66a су Оливер
Каудери.

“ангижралын төлөөх ^ббаптисмын талаар Их Эзэнээс асуухын тулд бид нэг өдөр ой уруу явлаа. Бид ийнхүү залбирч мөн Их Эзэнийг дуудаж байтал тэнгэрээс нэгэн ^аэлч гэрэлт ‘үүлэн дотор доош буун ирж, бидэн дээр ^бгараа тавиад тэрбээр биднийг ^атомилон хэлсэн нь:

69 Миний нөхөд үйлчлэгч та нарт би Мессиагийн нэрээр, тэнгэр элчүүдийн тохинууллын хийгээд наманчлалын сайн мэдээний, мөн нүглүүдийн ангижралын тулд усанд умбуулалтаар хийх баптисмын тулхүүрүүдийг атгагч ‘Аароны санваар хүртээж байна; мөн энэ нь ^бЛевийн хөвгүүд Их Эзэнд зөв шударга байдалд дахин өргөл өргөх хүртэл дэлхийгээс хэзээ ч дахин авагдахгүй байх болно.

70 Аароны санваар нь Ариун Сүнсний “бэлгийн тулд гар

тавих хүчгүй, гэвч энэ нь бидэнд үүнээс хойш хүртээгдэх болно гэдгийг тэрбээр хэлэв, мөн бид явж мөн баптисм хүртэхийг тэрээр бидэнд зарлиглаж, тэгээд би Оливер Каудерид баптисм хүртээх ёстой, мөн үүнчлэн дараа нь тэрээр надад баптисм хүртээх ёстой хэмээх чиглүүллийг бидэнд өгөв.

71 Тэр дагуу бид явж мөн баптисм хүртэв. Эхлээд би түүнд баптисм хүртээв, тэгээд дараа нь тэр надад баптисм хүртээж — үүний дараа би түүний толгой дээр гараа тавьж мөн түүнийг Аароны санваарт томилов, мөн дараа нь тэрээр над дээр гараа тавьж мөн намайг энэ санваарт томилов — учир нь бидэнд ийн зарлиг болгосон бөлгөө.*

72 Энэ үйл явдлаар бидэнтэй уулзаж мөн бидэнд энэхүү

*Оливер Каудери эдгээр үйл явдлуудыг ийн дүрсэлжээ: “Тэнгэрийн нөлөөгөөр дуудан өгүүлэх дуу хоолойн дуун дор сууж, энэхүү үйл явдлын дээд баяр талархлыг мэдэрсэн эдгээр өдрүүд хэзээ ч мартагдах аргагүй юм! Урим ба Туммиаар, эсвээс ‘хөрвүүлэгчид’ хэмээн нифайчууд хэлдэг байсан түүгээр ‘Мормоны Ном’ гэж нэрлэгдсэн тэрхүү түүх буюу цэдгийг тэрээр орчуулж байхад нь би түүний хэлснийг өдөр бүр тасалдалгүйгээр бичиж байлаа.

“Мормон болон түүний итгэлтэй хүү Моронайн өгүүлсэн, нэгэн цагт тэнгэрийн хайр, ивээлд байсан хүмүүсийн тухай сонирхолтой шастирыг хэдхэн үгээр тэмдэглэн хэлэхэд миний эдүгээгийн төсөөллийг орлохуйц байжээ; тиймийн тул би үүнийг ирээдүй үед хойшлуулъя, мөн би оршилд өгүүлсэнчлэн, урагшаа алхан, өөрийнхөө итгэл бодлоор зөрүүдлэн мугуйдлагчдын хөмсөг зангидалт хийгээд хоёр нүүртнүүдийн гүтгэлгийн дунд Христийн Сайн мэдээг тэврэн авсан хэдэн мянган хүмүүсийг баяр-

68a су Нүглүүдийн ангижрал.
б су Баптисм, Баптисм хүртээх.
в су Иохан Баптист.
г Тоол. 11:25;

Ифер 2:4–5, 14;
С ба Г 34:7.
д ИТ 5. су Гар тавих.
е су Эрх мэдэл;
Томилох, Томилолт.
69a су Аароны санваар.

б Дэд хууль 10:8;
С ба Г 13; 124:39.
су Леви—Левийн овог.
70a су Ариун Сүнсний бэлэг.

санваарыг хүртээж, мөнөөх тэнгэр элч, Шинэ Гэрээнд “Иохан Баптист хэмээн нэрлэгддэг тэрхүү Иохан хэмээн нэрээ хэлж, мөн цаг нь болохоор бидэнд хүртээгдэх ^бМелкизедек санваарын ^втүлхүүрүүдийг атгадаг ^гПетр, ^дИаков ^еИохан нарын удирдлага дор ажиллаж байгаагаа, түүнчлэн ингэснээр би Сүмийн анхны ^жахлагч, харин тэрээр (Оливер Каудери) хоёр дахь нь хэмээн нэрлэгдэх болно гэж хэлэв. Энэхүү элчийн гар дор бид томилогдон, мөн баптисм хүртсэн нь 1829 оны тавдугаар сарын арван тавны өдөр байлаа.

73 Бид баптисм хүртсэний дараа уснаас гарч ирсэн тэр даруйд бид Тэнгэрлэг Эцэгийнхээ агуу хийгээд алдар суут адислалуудыг мэдрэв. Бибээр Оливер Каудерид

баптисм хүртээж мөн “Ариун Сүнс түүн дээр ирээд тун удаагүй байхад мөн тэрээр босч, удахгүй тохиохоор ирэх ёстой олон зүйлийг ^ббошиглов. Мөн дахин бибээр түүгээр баптисм дөнгөж хүртээгдмэгц, бас бошиглолын сүнстэй болж, босоод энэ сүмийн өсөн мандалт хийгээд Сүмтэй холбоотой бусад олон зүйлийн талаар түүнчлэн хүмүүний үрсийн энэ үеийнхний талаар бошиглов. Бид Ариун Сүнсээр дүүрч, мөн авралынхаа төлөө Бурханд баясав.

74 Эдүгээ бидний оюун гэгээрч, бидний “ойлголтод нээгдсэн судрууд бидэнд бий болон, мөн тэдгээрийн илүү нууцлаг хэсгүүдийн ^бжинхэнэ утга хийгээд зорилго урьд нь бидний хэзээ ч мэдэхгүй байсан, өмнө нь бидний хэзээ

луулсан байх учиртай энэ Сүмийн өсөлт хөгжилтэй шууд холбоо бүхий зарим нэг үйл явдлууд уруу шууд оръё.

“Ялангуяа хүмүүний дундах ялзрал нь бүхий л хэлбэрүүд хийгээд тогтолцоогоороо тодорхойгүй байдлыг бий болгосон үед, Есүс Христийн амилалтаар ирдэг сайн ухамсарт хариулахын тулд, шингэн булшинд оршуулагдсанаараа зүрх сэтгэлийнхээ хүслийг үзүүлэх онцгой хүсэлгүйгээр хүмүүн өөрийн эрүүл саруул ухаанаар Аврагчийн амнаас нифайчуудад өгсөн удирдамжуудыг хүмүүн Түүний сүмийг байгуулах тод томруун арга маягийн тухай орчуулж мөн бичиж чадах нь үгүй бөлгөө.

Энэ тив дээр Иаковын үр удмын үлдэгдэлд хийсэн Аврагчийн тохиууллын шастирыг бичсэн дараа, дэлхийг харанхуй бүрхэж мөн түнэр харанхуй нь хүмүүсийн оюуныг бүрхсэн адил энэ нь тохиох болно хэмээн бошиглогчийн хэлсэнчлэн, харахад төвөггүй байв. Цаашид бодож үзэх юм бол шашинтай холбогдох агуу тэмцэл хийгээд шуугианы дунд, Сайн мэдээний ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдлийг Бурханаас хүлээж авсан хүн

72a су Иохан Баптист.

б су Мелкизедек санваар.

в су Санваарын түлхүүрүүд.

г С ба Г 27:12–13.

су Петр.

д су Иаков, Зебедийн хүү.

е су Иохан, Зебедийн хүү.

ё су Ахлагч.

73a су Ариун Сүнс.

б су Бошиглох, Бошиглол.

74a су Мэдлэг.

б Иохан 16:13.

ч бодож байгаагүй тийм байдлаар бидэнд илчлэгдсэн болой. Тэр хавьд аль хэдийн мэдэгдсэн мөрдлөг хавчлагын сүнсний улмаас санваар хүлээж авсан хийгээд бид баптисм хүртсэн нөхцөл байдалаа бид тэр үед нууц байлгахаас аргагүйд хүрсэн юм.

75 Танхайрагч бүлгүүд, мөн үүнчлэн сүсэг бишрэлийг тунхаглагчид ч биднийг үе үе, халдан дайрч, заналхийлж байлаа. Мөн надад нэн нөхөрсөг болж, мөн дур зоргоо-

роо авирлагчдын эсрэг байж, бас орчуулгын ажлыг тасалдуулалгүй үргэлжлүүлэх боломжийг надад өгөхөд бэлэн байсан, тиймийн тул, боломжийнхоо хэрээр бүхий л хууль бус үйлдлүүдээс биднийг хамгаалахыг санал болгож мөн амласан миний эхнэрийн эцгийн гэр бүлийнхний нөлөөгөөр (Тэнгэрлэг санаа тавилтаар) л бидэнд халдан дайрах тэдний санаархал гагцхүү саатуулагдаж байлаа.

байхгүй байлаа. Учир нь дэлхийн бүхий л үеүдэд Тэрбээр дэлхий дээрх хүмүүстэй хамт байгаа үед, Түүний шашин, тэр даруйд ирэх илчлэлтүүд дээр үндэслэгдэн төлөвшиж, мөн дэмжигддэг Христийн нэрийг хэрэглэх эрх мэдэл, илчлэлтүүдийг үгүйсгэдэг хүмүүст байх уу гэдэг асуулт тавигдаж болох юм. Хэрэв эдгээр баримтууд оршуулагдсан, мөн ов мэх нь аюулд хүргэж болох хүмүүсээр хичээнгүйлэн далдлагдах аваас, хэрэв нэгэнтээ хүмүүсийн нүүрэн дээр гэрэлтүүлэх аваас, тэдгээр нь хэрхэвч бидэнд биш байлаа; мөн 'Босч мөн баптисм хүрт' хэмээх зарлиг өгөгдөхийг л зөвхөн бид хүлээж байв.

Энэ нь мэдэгдэхээс өмнө удаан хугацаанд хүсэгдэж байгаагүй билээ. Хүмүүсийн гэр орноос хол зайд, нигүүлслээр баян, даруу хүмүүсийн байнгын залбиралд хариулахад ямагт бэлэн Их Эзэн, Түүнийг бид бадрангуй маягаар дуудсаны дараа, Өөрийнхөө тааллыг бидэнд илэрхийлэхээр зөвшөөрсөн билээ. Гэнэт мөнх оршихуйн гүнээс Аврагчийн дуу хоолой бидэнд амар амгаланг ярьж байхад, хөшиг хуваагдан мөн алдар суугаар хувцасласан Бурханы тэнгэр элч доош бууж ирэн, хүсэмжлэн байсан мэдэгдлийг болон наманчлалын Сайн мэдээний түлхүүрүүдийг хүргэн ирэв. Ямар баяр хөөр! Ямар гайхамшиг! Ямар гайхалтай вэ! Энэ дэлхийнхэн зовж мөн үймүүлэгдэж — сая сая хүн сохор мэт хана дагуу тэмтэрч байхад, мөн бүх хүмүүс олноороо тодорхой бус зүйл дээр найдаж байхад цэлмэг өдрийн гэрэл адил бидний нүд болгоож, бидний чих сонссон билээ, тийм ээ, илүүгээр — тавдугаар сарын нарны туяанаас ч хурц гялалзаж, тэгээд сүүдрүүд нь байгалийн нүүрэн дээгүүр гялалзан байв! Тэгээд түүний дуу хоолой, намуухан хэдий ч биеийн төвд нэвтрэн, би чиний хамтран зүтгэгч хэмээх түүний үг бүх айдсыг үргээв. Бид сонсож, бид цоо ширтэн харж, бид гайхацгаав! Энэ бол алдар суугаас ирсэн тэнгэр элчийн дуу хоолой байлаа, энэ бол Бүхний Дээдээс ирсэн захиас байлаа! Мөн Түүний хайр бидний бие махбодь дээр дүрэлзэхэд бид сонссондоо баяр хөөртэй байв, мөн бид Бүхнийг Чадагчийн үзэгдэлд ороогдсон байв. Эргэлзэх зай тэнд байсан уу? Хаана ч байгаагүй; худал зүйл болон хууран мэхлэх явдал үүрд зугтан одох үед тодорхой бус зүйл зугтан одов, эргэлзээ хэзээ ч босож ирэхгүйгээр живэв.

Гэвч, хайрт ах дүүс минь, биднийг түүний гар дор Ариун санваар

хүлээн авахад тэрээр, ‘Левийн хөвгүүд Их Эзэнд зөв шударга байдалд өргөл өргөх учиртай, энэ дэлхий дээр үлдэх энэхүү санваар хийгээд эрх мэдлийг миний нөхөд үйлчлэгч та нарт би Мессиагийн нэрээр хүртээж байна’ хэмээн түүнийг хэлэхэд (учир нь хэн ийм адислалд өвдөг сөхрөхгүй байх билээ?) бидний зүрх сэтгэл ямархуу баяр баяслаар дүүрснийг, мөн ямархуу гайхашралд бид мэхийх ёстой болсныг хормын төдий ч атугай бодооч, цааш нь бодоод үзээч!

“Зүрх сэтгэлийн энэхүү мэдрэмжийг, бас энэ шалтгааны улмаас, уг үйл явдлын үеэр биднийг хүрээлсэн сүр жавхлантай гоо үзэсгэлэн хийгээд алдар сууг би та нарт дүрслэхийг хичээхгүй; харин дэлхий ч, хүмүүс ч, үзэл санааг уран гоёор илэрхийлэх хуримтлуулсан туршлагаараа, энэ ариун хүн шиг хэлийг тийм сонирхолтой хийгээд урам хайрласан, сэтгэл догдлом байдалаар илэрхийлж үл чадна хэмээн намайг хэлэхэд та нар итгэх үү. Үгүй ээ; энэ дэлхий баяр хөөр өгөх, амар амгаланг бэлэглэх хүчгүй, эсвээс үгс нь Ариун Сүнсний хүчээр хэлэгдсэн үед өгүүлбэр бүрд агуулагдсан мэргэн ухааныг ойлгох нь үгүй бөлгөө! Хүн өөрийн нөхөд — хүмүүсийг мэхэлж болно, нэг мэхлэлт нөгөөгөө дагалдаж болно, тэрчлэн ёс бус нэгний хүүхдүүд мунхаг хийгээд боловсролгүй нэгнээ юу ч үгүй болтол уруу татаж болно, харин худал хуурмаг нь олныг хөхиүлэн тэтгэж байна, түүнчлэн худал хуурмагийн үр жимс гэнэн итгэмтгий нэгнийг өөрийн урсгалаар булш уруу тээж аваачдаг буюу; гэвч түүний хайрын хуруунд ганц удаа хүрэх нь, тийм ээ, дээд дэлхийгээс ирэх алдар суугийн ганц туяа, эсвээс Аврагчийн амнаас, үүрд мөнхийн цээжнээс ирэх ганц үг нь энэ бүгдийг ач холбогдолгүй болгож, үүнийг оюунаас үүрд зайлуулдаг бөлгөө. Бид тэнгэр элчийн дэргэд байсан тухай баттай мэдлэг, Есүс Христийн дуу хоолойг сонссон тодорхой байдал, түүнчлэн Бурханы хүсэл зоригоор хэлэгдэн, ариун хүнээс цутган ирэх лугаа адил толботоогүй үнэн нь миний хувьд өнгөрсний дүрслэл ажгуу, мөн бибээр үлдэхийг зөвшөөрөгдсөн үедээ Аврагчийн уужуу сэтгэлийн энэхүү илэрхийллийг гайхамшиг хийгээд баяр талархалтайгаар цаг ямагт харах болно; түүнчлэн төгс байдал оршдог мөн нүгэл хэзээ ч ордоггүй тэрхүү харшуудад, хэзээ ч төгсөх нь үгүй тэрхүү өдөр шүтэн бишрэхэд бибээр найднам.” — *Messenger and Advocate*, боть 1 (1834 оны арвдугаар сар), хууд. 14–16.

ИТГЭЛИЙН ТУНХАГ

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

History of the Church, Боть 4, хуудас 535–541

“БУРХАН, Мөнхийн Эцэг, мөн Түүний ⁶Хүү Есүс Христ, мөн ⁶Ариун Сүнсэнд бид ¹итгэдэг.

2 Адамын ⁶зөрчлийн улмаас бус, хүмүүн ⁶өөрсдийнхөө нүглүүдийн улмаас шийтгэгдэх болно гэдэгт бид итгэдэг.

3 Христийн ⁶Цагаатгалаар дамжин Сайн мэдээний ⁶хуулиуд хийгээд ⁶ёслолуудад ⁶дуулгавартай байснаар бүх хүн төрөлхтөн ⁶аврагдана гэдэгт бид итгэдэг.

4 Сайн мэдээний анхдагч зарчмууд хийгээд ⁶ёслолууд нь: нэгдүгээрт, Их Эзэн Есүс Христэд итгэх ⁶итгэл; хоёрдугаарт, ⁶Наманчлал; гуравдугаарт, Нүглүүдийн ⁶ангиж-

ралын төлөөх усанд умбуулах ⁶баптисм; дөрөвдүгээрт, Ариун Сүнсний ⁶бэлгийн төлөөх ⁶гар тавилт гэдэгт бид итгэдэг.

5 Сайн мэдээг ⁶номлох хийгээд үүний ⁶ёслолуудыг гүйцэтгэхийн тулд хүн ⁶бошиглогоор, мөн ⁶эрх мэдэл бүхий тэдний ⁶гар тавилтаар Бурханаас ⁶дуудагдах ёстой гэдэгт бид итгэдэг.

6 Анхны Сүмд байсан тэрхүү ⁶зохион байгуулалтад, тухайлбал ⁶төлөөлөгчид, ⁶бошиглогчид, ⁶пасторууд, багш нар, ⁶евангелистууд болон бусдад бид итгэдэг.

7 ⁶Хэлний, ⁶бошиглолын, ⁶илчлэлтийн, ⁶үзэгдлийн, ⁶эд-

1a су Бурхан, Бурхан тэргүүтэн — Эцэг Бурхан.

б су Бурхан, Бурхан тэргүүтэн — Хүү Бурхан; Есүс Христ.

в су Бурхан, Бурхан тэргүүтэн — Бурхан Ариун Сүнс; Ариун Сүнс.

г су Итгэлтэй байх, Итгэл.

2a су Адам, Ева хоёрын уналт.

б Дэд хууль 24:16; Езек. 18:19–20. су Хариуцах, Хариуцлага, Хариуцлагатай; Сонгох эрх.

3a су Цагаатгах, Цагаатгал.

б су Хууль.

в су Сайн мэдээ.

г су Дуулгавартай байх, Дуулгавартай, Дуулгавартай дагах.

д Мозая 27:24–26; Мосе 5:9.

е су Аврал.

4a су Ёслолууд.

б су Итгэл.

в су Наманчлах, Наманчлал.

г су Нүглүүдийн ангижрал.

д су Баптисм, Баптисм хүртээх.

е су Ариун Сүнсний бэлэг.

ё су Гар тавих.

5a су Номлох.

б Алма 13:8–16.

в су Бошиглох, Бошиглол.

г су Эрх мэдэл;

Санваартан.

д су Гар тавих.

е су Дуудах, Бурханаас дуудагдах, Дуудлага.

6a су Үнэн Сүмийн тэмдгүүд — Сүмийн зохион байгуулалт.

б су Төлөөлөгч.

в су Бошиглогч.

г су Бишоп.

д су Сургаал

номлогч;

Патриарх,

Патриархын.

7a су Хэлний бэлгүүд.

б су Бошиглох,

Бошиглол.

в су Илчлэлт.

г су Үзэгдэл.

д су Эдгээх, Эдгэрэх.

гээхийн, хэлнүүдийн “хөрвүүлгийн болон бусад” бэлэгт бид итгэдэг.

8 “Библи” зөв орчуулагдсан байхын хэрээр Бурханы “үг мөн гэдэгт бид итгэдэг; тэрчлэн “Мормоны Ном бол Бурханы үг мөн гэдэгт бид итгэдэг.

9 Бурханы “илчилсэн бүгдэд, эдүгээ түүний илчилж буй бүгдэд бид итгэдэг, мөн Бурханы хаант улсад хамаарах олон агуу хийгээд чухал зүйлийг Тэрээр цаашид “илчлэх болно гэдэгт бид итгэдэг.

10 Израил жинхэнэ ёсоор “нэгдэж, мөн “Арван овог дахин сэргэж, “Сион (Шинэ Иерусалим) Америк тивд байгуулагдах болно гэдэгт; Христ дэлхий дээр өөрийн биеэр “хаанчлах болно гэдэгт; мөн дэлхий “шинэчлэгдэж мөн “диваажингийн “алдар суугаа хүлээн авах болно гэдэгт бид итгэдэг.

11 “Ухамсрынхаа “шаардлагын дагуу Бүхнийг Чадагч Бурханыг “шүтэн бишрэх “онцгой

боломжийг бид шаардаж байна, мөн энэхүү онцгой боломжийг бүх хүмүүст зөвшөөрч, хэрхэн, хаана, эсвээс юуг шүтэн бишрэх нь тэдний хэрэг гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

12 Хаад, ерөнхийлөгчид, удирдагчид, мөн шүүгчдэд захирагдаж “хуулийг дуулгавартай дагаж, хүндлэн дээдэлж, мөн дэмжих ёстой гэдэгт бид итгэдэг.

13 “Шударга, үнэнч, “ариун явдалтай, нинжин сэтгэлтэй, ач буянтай байхад мөн бүх хүмүүст сайн сайхныг “үйлдэхэд бид итгэдэг; чухамдаа—бид бүх зүйлд итгэдэг, бид бүх зүйлд “найддаг, бид олон зүйлийг хүлцэн тэвчлээ, мөн бүх зүйлийг “хүлцэн тэвчих болно гэдэгт найддаг гэсэн Паулын “зөвлөгөөг бид дагадаг хэмээн хэлж болно. Хэрэв “ариун журамтай, сайхан, эсвээс сайн гэгддэг буюу сайшаалтай ямар нэгэн зүйл байдаг бол, бид эдгээр зүйлүүдийг эрэлхийлдэг.

Иосеф Смит

7e 1 Кор. 12:10;
Морм. 9:7–8.
ё су Сүнсний бэлгүүд.
8a су Библи.
б 1 Ниф. 13:20–40;
14:20–26.
в су Бурханы Үг.
г су Мормоны Ном.
9a су Илчлэлт.
б Амос 3:7;
С ба Г 121:26–33.
су Судрууд—Ирнэ хэмээн бошиглогдсон судрууд.
10a Иса. 49:20–22; 60:4;
1 Ниф. 19:16–17.
су Израил—Израилын цугларалт.

б су Израил—Израилын алдагдсан арван овог.
в Ифер 13:2–11;
С ба Г 45:66–67;
84:2–5;
Моце 7:18.
су Шинэ Иерусалим; Сион.
г су Мянган жил.
д су Дэлхий—Дэлхийн цэвэршилт.
е ө.х. Еденийн цэцэрлэгтэй адил нөхцөл байдал, Иса. 11:6–9; 35:1–10; 51:1–3; 65:17–25; Езек. 36:35.

су Диваажин.
ё су Алдар суу.
11a су Ухамсар.
б С ба Г 134:1–11.
в су Шүтэн бишрэх.
г су Сонгох эрх.
12a С ба Г 58:21–23.
су Хууль.
13a су Үнэнч, Үнэнч шударга; Зарчимч байдал.
б су Ариун явдал.
в су Үйлчлэл.
г су Найдвар.
д су Тэвчих.
е Филип. 4:8.
ё су Төлөв зан;
Нөлөөлөх хүч.

Судруудын Удирдамж

УДИРТГАЛ

ЦАГААН ТОЛГОЙН ДАРААЛЛААРХ
СЭДВҮҮДИЙН ЖАГСААЛТ

БИБЛИЙН ИОСЕФ СМИТИЙН ОРЧУУЛГАНААС
АВСАН ХЭСЭГ

СҮМИЙН ТҮҮХИЙН ОН ДАРААЛАЛ, ИОСЕФ СМИТИЙН
БИБЛИЙН ОРЧУУЛГА

БИБЛИЙН ГАЗРЫН ЗУРАГ БОЛОН ГЭРЭЛ ЗУРГУУД

УДИРТГАЛ

Судруудын Удирдамж нь Ариун Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, түүнчлэн Агуу Үнэт Сувдад гардаг түүвэрлэн сонгож авсан сургаалууд, зарчмууд, хүмүүс болон газар нутгууд юм. Тэрчлэн энэ нь сэдэв бүрийг судлахад зориулсан судруудын гол чухал ишлэлүүдээр таныг хангадаг. Удирдамж нь хувиараа болон гэр бүлээрээ судруудыг суралцахад тань танд тусалж чадна. Энэ нь сайн мэдээний асуултууд, судрууд дахь судалгааны сэдвүүдэд хариулах, яриа болон хичээлүүд бэлтгэх, мөн сайн мэдээний талаарх мэдлэг хийгээд гэрчлэлээ нэмэгдүүлэхэд тань танд тусалж чадна.

Удирдамж гурван хэсэгтэй: (1) Сэдвүүдийн цагаан толгойн дарааллаарх жагсаалт, (2) Библийн Иосеф Смитийн орчуулгаас авсан цуглуулгууд (ИСО), (3) газрын нэрсийн товъёог бүхий газрын зургууд, түүнчлэн судруудад холбогдох газруудын гэрэл зургууд.

1. *Цагаан толгойн дарааллаарх сэдвүүдийн жагсаалт.* Энэ хэсэг нь сэдэв бүрийн товч тодорхойлолт, түүнчлэн тухайн сэдвийн талаарх судруудын хамгийн чухал ишлэлүүдийн жагсаалтыг агуулдаг. Ишлэл бүрийн өмнө тухайн судрын товч иш таталт буюу хураангуйлал бий. Судрын ишлэлүүд доорх дарааллаар орсон байгаа, үүнд: Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд.

2. *Библийн Иосеф Смитийн орчуулгаас авсан цуглуулгууд.* 1830 онд Их Эзэн, Библийн Хаан Жеймсийн Хувилбарыг дахин хянах буюу орчуулах ажлыг эхлэхээр Бошиглогч Иосеф Смитэд зааварлажээ. Библийн эх бичвэрүүдээс хаягдсан зарим тодорхой хийгээд эрхэм үнэнүүдийг сэргээх нь Бошиглогчийн зорилго байлаа. Тэрээр ажлын ихэнхийг 1833 оны долдугаар сар гэхэд дуусгажээ. Гэвч, 1844 онд түүнийг нас барах хүртэл, гар бичмэлийг хэвлэхэд бэлтгэн өөрчлөлт засвар хийхээ үргэлжлүүлсээр байв. Боть бүхэлдээ дуусаагүй, мөн энэ нь Сүмээр албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөөгүй байсан хэдий ч Иосеф Смитийн Орчуулга нь судруудын утгад зарим нэг ойлголтуудыг оруулсан бөгөөд Библийг ойлгоход үнэтэй тусламж болдог. Зарим нэг чухал засварууд Судруудын Удирдамжид орсон юм. (Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Удирдамж дахь Иосеф Смитийн Орчуулгаас үзнэ үү.)

Есүс Христийн Хожмын Уеийн Гэгээнтнүүдийн Сүм, Библийн Хаан Жеймсийн Хувилбарын Англи орчуулгыг албан ёсоор хэрэглэдэг. Энэ нь сайн мэдээний сэргэлтэд үндсэн гол үүрэг гүйцэтгэж, мөн дэлхий даяар олон үндэстнүүдэд чухал нөлөө үзүүлсээр байгаа билээ. Газар нутгийн нэрсийн товъёог бүхий газрын зургууд судруудад гардаг нэн чухал ач холбогдол бүхий газар зүйн байрлалуудыг л зөвхөн газрын зургуудад оруулсан болно.

3. *Сүмийн Түүхийн он дараалал, газрын зураг, болон гэрэл зургууд ба Библийн газрын зураг мөн гэрэл зургууд.* Судруудад гардаг нутгуудын газарзүйг мэдсэнээр та судрын үйл явдлуудыг илүү сайн ойлгож чадна. Удирдамжид Библийн зургаан газрын зураг түүнчлэн Есүс Христийн Хожмын Уеийн Гэгээнтнүүдийн Сүмийн түүхэнд чухал ач холбогдол бүхий газруудын дөрвөн зураг байдаг. Газарзүйн байрлалуудыг олохын тулд товъёогт ханд. Товъёог нь таныг холбогдох газрын зураг хийгээд тухайн газрын зураг дээрх байршлын солбилцлуудыг танд харуулах болно. Судруудад холбогдох газруудын гэрэл зургууд судруудтай холбоотой чухал газруудын эдгээр гучин хоёр гэрэл зураг нь Есүсийн алхалж явсан, түүний бошиглогчдын амьдарч мөн зааж байсан газрууд, түүнчлэн судрын олон үйл явдал болсон газруудыг танд нээж өгч чадна. Гэрэл зургуудыг тэдгээрийн товч тодорхойлолт мөн уг бүсэд болсон судрын хамгийн чухал

явдлууд аль аль нь дагалддаг. Эдгээр нь судрууд хийгээд тэдгээрийн хэрэгжсэн газар нутгуудын хоорондын ойрын хэлхээ холбоог мэдэж авахад танд тусалж чадна.

Судруудыг судлахад танд тус дөхөм үзүүлэхийн тулд Удирдамж нь ашиг тустай бусад хэдэн онцлогтой. Жишээ нь, хэрэв та Есүс Христ тайлбар бичвэрийг үзэх юм бол Аврагч хийгээд түүний тохинуулалд шууд хамаарах мэдээллээр хангадаг, удирдамж дахь сэдэв бүрийн олон талыг хамарсан жагсаалтыг олж үзэх болно. Энэ бол бүх хүн төрөлхтний хувьд Христийн ач холбогдлыг товойлгон харуулсан ийм дэлгэрэнгүй жагсаалт бүхий Удирдамж дахь цорын ганц сэдэв юм. Түүнээс гадна, Он дараалал сэдэвт Библийн хийгээд Мормоны Номын үед болсон нэн чухал зарим үйл явдлыг холбогдох онуудын хамт жагсаасан болно.

“Сайн мэдээнүүд” сэдэв нь сайн мэдээтэй нийцсэн байгаа. Энэхүү зохицол нь Матай, Марк, Лук Иохан дахь Аврагчийн заадаг зүйлүүд хийгээд хошмын үеийн илчлэлтийг харьцуулж үзсэн болно.

Удирдамжид судрын номнуудын дараах товчлолуудыг ашигласан болно.

Хуучин Гэрээ

Эхлэл	Эхл.
Египетээс Гарсан нь	Ег.
Левит	Лев.
Тооллого	Тоол.
Дэд хууль	Дэд хууль.
Иошуа	Иош.
Шүүгчид	Шүүгч.
Рут	Рут
1 Самуел	1 Сам.
2 Самуел	2 Сам.
Хаадын дээд	Хаад. дээд
Хаадын дэд	Хаад. дэд
Шастирын дээд	Шаст. дээд
Шастирын дэд	Шаст. дэд
Езра	Езра
Иехемиа	Иехе.
Естер	Ест.
Иов	Иов
Дуулал	Дуул.
Сургаалт үгс	Сур. үгс
Номлогчийн үгс	Ном. үгс
Соломоны дуун	Сол. дуу.
Исаиа	Исаиа
Иеремиа	Иерем.
Иеремиагийн гашуудал	Иер. гаш.
Езекиел	Езек.
Даниел	Дан.
Хосеа	Хосеа
Иоел	Иоел
Амос	Амос
Обадиа	Обад.
Иона	Иона
Мика	Мика

Нахум	Нахум
Хабаккук	Хабак.
Зефаниа	Зефан.
Хаггаи	Хаг.
Зехариа	Зехар.
Малахи	Малах.

Шинэ Гэрээ

Матай	Мат.
Марк	Марк
Лук	Лук
Иохан	Иохан
Үйлс	Үйлс
Ром	Ром
1 Коринт	1 Кор.
2 Коринт	2 Кор.
Галат	Гал.
Ефес	Еф.
Филиппой	Фил.
Колосай	Колос.
1 Тесалоник	1 Тес.
2 Тесалоник	2 Тес.
1 Тимот	1 Тим.
2 Тимот	2 Тим.
Тит	Тит
Филемон	Филе.
Еврей	Евр.
Иаков	Иаков
1 Петр	1 Петр
2 Петр	2 Петр
1 Иохан	1 Иохан
2 Иохан	2 Иохан
3 Иохан	3 Иохан
Иуда	Иуд.
Илчлэлт	Илч.

Мормоны Ном		Сургаал ба Гэрээ	С ба Г
1 Нифай	1 Ниф.	Албан Тунхаг—1	АТ—1
2 Нифай	2 Ниф.	Албан Тунхаг—2	АТ—2
Иаков	Иаков		
Инос	Инос	Агуу Үнэт Сувд	
Жером	Жер.	Мосе	Мосе
Омнаи	Омн.	Абрахам	Абр.
Мормоны Үгс	Мор. үгс	Иосеф Смит—Матай	ИС—Мат.
Мозая	Моз.	Иосеф Смит—Түүх	ИС—Т
Алма	Алма	Итгэлийн Тунхаг	ИТ
Хиламан	Хил.		
3 Нифай	3 Ниф.	Иосеф Смитийн	
4 Нифай	4 Ниф.	Орчуулга	ИСО
Мормон	Морм.		
Ифер	Ифер		
Моронай	Моро.		

ЦАГААН ТОЛГОЙН ДАРААЛЛААРХ СЭДВҮҮДИЙН ЖАГСААЛТ

Хэрхэн ашиглах нь. Судруудын удирдамж нь сайн мэдээний сэдвүүдийн цагаан толгойн дарааллаарх жагсаалт юм. Энэ нь сэдэв бүрийн талаар богино хэмжээний тайлбаруудыг өгөх бөгөөд тухайн сэдвийн хамгийн онцгой судруудаар хангах болно. Судрын ишлэл бүр тухайн судрын талаарх богино хэмжээний ишлэл болон хураангуйгаас бүрдсэн байгаа. Судруудын ишлэл нь: Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ болон Агуу Үнэт Сувд гэсэн дарааллаар бичигдсэн. Доорх бүдүүвч оруулга хэрхэн байрласныг тайлбарлав.

Сэдвүүд нь тодоор том үсгээр бичигдсэн.

Сэдэв бүр товч тайлбартай.

Зарим сэдвүүд нь хам сэдэвтэй. Тэдгээр нь бичмэл үсгээр бичигдсэн болно.

Ижил утгатай судрын тайлбарыг хаалтан дотор хийсэн болно.

Заримдаа та нарын хайж буй сэдэвтэй холбоотой мэдээлэл тухайн сэдэвт байхгүй байж болох юм. Бичмэлээр үз гэсэн нь тэрхүү мэдээллийг агуулсан сэдэв уруу та нарыг аваачих болно.

ГАЗАР ДЭЛХИЙ. Бүтээх, Бүтээлт, Дэлхийг мөн үз

Хүмүүн мөнх бус сорилтынхоо туршид ашиглахаар Есүс Христээр дамжуулан Бурханы бүтээсэн бидний амьдардаг гараг. Үүний эцсийн хувь тавилан нь алдар сууд хүрч өргөмжлөгдөх явдал мөн (С ба Г 77:1–2; 130:8–9). Селестиел алдар суугийн тул зөв зохистой амьдарсан хүмүүсийн мөнхийн өв болох болно (С ба Г 88:14–26). Тэд Эцэг болон Хүүгийн оршихуйд баяртай байх болно (С ба Г 76:62).

Хүмүүний тул бүтээгджээ: Бурхан хүмүүнд дэлхий дээрх эрх мэдлийг өгөв, **Эхл.** 1:28 (Моисе 2:28). Газар дэлхий нь Их Эзэнийх, **Ег.** 9:29 (Дуул. 24:1). Их Эзэн газар дэлхийг хүмүүний үрст өгчээ, **Дуул.** 115:16. Би газар дэлхийг бий болгож мөн үүн дээр хүнийг бүтээсэн, **Иса.** 45:12. Түүний үгийн хүчээр хүн газар дэлхий дээр ирсэн юм, **Иаков** 4:9. Газар дэлхий нь Ариун Сүнснийг өөрсдийнхөө хөтөч болгосон тэдэнд өгөгдөх болно, **С ба Г** 45:56–58 (С ба Г 103:7). Сайн мэдээг дагасан тэд газар дэлхийн сайн зүйлсээр шагнагдсан билээ, С ба Г 59:3. Газар дэлхийн ядуус хийгээд хүлцэнгүй тэд үүнийг өвлөх болно, **С ба Г** 88:17 (Мат. 5:5; 3 Ниф. 12:5). Бид газар дэлхийг бий болгож мөн бид тэднийг нотлох болно, **Абр.** 3:24–25.

УЛААН ӨНДӨГНИЙ БАЯР. Есүс Христ, Амилалтыг үз

ДЭЛХИЙН ТӨГСГӨЛ. Дэлхий Дэлхийн төгсгөлийг мөн үз

Заримдаа удирдамж доторх өөр сэдэв та нарын судалж буй сэдвийг агуулж байж болох юм.

Бичмэлээр үз гэсэн нь тэрчлэн тухайн мэдээллийг агуулсан сэдэв уруу та нарыг аваачих болно.

Судруудын ишлэл нь хаалтанд буй тайлбарыг ойлгоход та нарт туслах болно.

Судрын тайлбар бүр судрын ишлэл буюу судрын хураангуйгаас бүрддэг.

Зураасны дараа бичмэлээр үз (эсвээс мөн үз) гэсэн нь тухайн мэдээллийг ижил утгатай сэдвээс олж болохыг харуулж буй (Дэлхийн төгсгөл) үүний үндсэн сэдэв нь (Дэлхий).

ААРОН, МОЗАЯГИЙН ХҮҮ.

Бенжаминь хүү Мозая;
Мозаягийн хөвгүүдийг *мөн үз*

Мормоны Номон дахь Хаан Мозаягийн хүү. Аарон номлогчоор үйлчилж байв, түүний хичээнгүй зүтгэл Христэд хөрвөхөд нь олон бодгальд тусалжээ.

Сүмийг устгахыг эрэлхийлж асан сүсэг бишрэлгүй нэгэн байжээ, **Моз.** 27:8–10, 34. Нэгэн тэнгэр элч түүн дээр болон түүний хамтрагчид дээр хүрч иржээ, **Моз.** 27:11. Наманчилж мөн Бурханы үгийг номлож эхлэв, **Моз.** 27:32–28:8. Хаан хэмээн нэрлэгдэхээс татгалзаж тэгээд үүний оронд Бурханы үгийг номлохоор леменчүүдийн нутаг уруу явжээ, **Алма** 17:6–9. Удирдамжийн тул мацаг барьж мөн залбирав, **Алма** 17:8–11. Хаан Лемонайн эцэгт заав, **Алма** 22:1–26. Зорамчуудад номлохоор одов, **Алма** 31:6–7.

ААРОН, МОСЕГИЙН АХ.

Аароны санваар; Мосег *мөн үз*

Хуучин Гэрээнд, Леви овгийн Амрам болон Иохебедийн хүү (Ег 6:16–20); Мосегийн том ах (Ег 7:7).

Израилын хүүхдүүдийг Египетээс гаргаж авчрахад нь болон түүний өмнөөс яригч байхад нь Мосед туслахаар Их Эзэнээр томилогдов, **Ег.** 4:10–16, 27–31; 5:1–12:51. Синай Уулан дээр Мосе Аарон болон түүний дөрвөн хүүг Аароны санваарт томилох тухай удирдамж хүлээн авчээ, **Ег.** 28:1–4. Хүмүүсийн хүсэлтээр алтан тугал хийжээ, **Ег.** 32:1–6, 21, 24, 35. 123 насандаа Хор Уулан дээр нас нөгчсөн ажгуу, **Тоол.** 20:22–29 (Тоол. 33:38–39). Их Эзэн санваарыг түүнчлэн Аарон болон түүний үр удамд хүртээжээ, **С ба Г** 84:18, 26–27, 30. Санваарын дуудлагаа хичээнгүйлэн гүйцэтгэдэг тэд Мосегийн хийгээд Аароны хөвгүүд болдог бөлгөө, **С ба Г** 84:33–34. Аароны адилаар Эцэгээр дуудагдсан тэдний зөв шударга үйл ажиллагааг Их Эзэн зөвтгөх болно, **С ба Г** 132:59.

ААРОНЫ САНВААР. Мосегийн ах Аарон; Мосегийн хууль; Санваарыг *мөн үз*

Доод санваар (Евр. 7:11–12; С ба Г 107:13–14). Үүний албан тушаалууд нь бишоп, санваартан, багш мөн дикон болой (С ба Г 84:30; 107:10, 14–15, 87–88). Эрт дээр үед Мосегийн хуулийн дагуу, дээд санваартнууд, санваартнууд, түүнчлэн левичүүд гэж байлаа. Эртний израилчууд Бурханы эсрэг боссоны улмаас Аароны санваар Мосед илчлэгджээ. Тэд ариусгагдахаас мөн Мелкизедек санваар болон үүний ёслолуудыг хүлээн авахаас татгалзсан ажээ. (С ба Г 84:23–25). Аароны санваар нь хуулийн хийгээд сайн мэдээний цаг зуурын болон гадна талын ёслолуудыг эрхэлдэг (Шаст. дээд 23:27–32; С ба Г 84:26–27; 107:20). Энэ нь тэнгэр элчийн тохинууллын, наманчлалын сайн мэдээний, түүнчлэн баптисмын түлхүүрүүдийг атгадаг (С ба Г 13). Аароны санваар нь энэ эрин үед 1829 оны тавдугаар сарын 15-нд дэлхийд сэргээгдсэн ажээ. Иохан Баптист үүнийг Иосеф Смит Оливер Каудери хоёрт Пеннсилванийн Хармонийн ойролцоо, Сасквиеханна голын эрэг дээр хүртээжээ (С ба Г 13; ИС—Т 1:68–73).

Мөн түүнд үүрдийн санваарын гэрээ байх болно, **Тоол.** 25:13. Их Эзэн Левийн хөвгүүдийг цэвэршүүлж, мөн тэднийг ангижруулан цэвэрлэх болно, **Малах.** 3:3 (3 Ниф. 24:3). Ямар ч хүн өөртөө энэ хүндлэлийг авдаггүй, **Евр.** 5:4. Төгс төгөлдөр байдал Левийн санваараар ирдэггүй, **Евр.** 7:11. Левийн хөвгүүд өргөл өргөх хүртэл энэ санваар дэлхийгээс хэзээ ч авагдахгүй, **С ба Г** 13:1. Иосеф Смит Оливер Каудери хоёр Аароны санваарт томилогдов, **С ба Г** 27:8. Доод санваар нь тэнгэр элчүүдийн тохинууллын түлхүүрийг атгадаг, **С ба Г** 84:26 (С ба Г 13:1). Хоёр санваар буй нь нэрлэвэл, Мелкизедек болон Аароны бөлгөө, **С ба Г** 107:1. Хоёр

дахь санваар нь Аароны санваар хэмээн нэрлэгддэг, **С ба Г** 107:13.

АБЕД-НЕГО. Даниелыг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Шадрах, Мешах болон Авед-него нь Даниелын хамт Вавилоны хаан Небухаднезарын ордонд аваачигдсан гурван залуу израилчууд байлаа. Авед-негогийн еврей нэр нь Азария байлаа. Эдгээр дөрвөн залуу эр хааны амттан шимтгэн болон дарснаас хувь хүртэж өөрсдийгөө бузарлахаас татгалзжээ (Дан.1). Шадрах, Мешах, Авед-него гурав дүрэлзсэн галтай зууханд хаанаар хаягдсан хэдий ч, Бурханы Хүүгээр аврагдан үлдсэн байлаа (Дан.3).

АБЕЛ. Адам; Каиныг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Адам Ева хоёрын нэг хүү.

Өөрийн ах Каинаас илүү онцгой өргөлийг Бурханд өргөжээ, **Эхл.** 4:4–5 (Евр.11:4, Мосе 5:16–21). Каинаар алагдав, **Эхл.** 4:8 (Мосе 5:32). Санваарыг Адамаас хүлээн авчээ, **С ба Г** 84:16. Абелыг алахын тулд Сатан Каинтай хуйвалдсан ажээ, **Мосе** 5:28–31 (Хил. 6:27).

АБИНАДАЙ. Алагдагч, Аллага, Амь насаараа хохирогчийг *мөн үз*

Мормоны Номон дахь нифайчуудын бошиглогч.

Хэрэв тэд үл наманчлах аваас ёс бус Хаан Ноагийн хүмүүсийг Бурхан цээрлүүлэх болно хэмээн бошиглогдог байв, **Моз.** 11:20–25. Хаан Ноа хийгээд түүний хүмүүсийн устгалыг бошиглогсны учир шоронд хоригдож байв, **Моз.** 12:1–17. Мосегийн хуулийн тухай мөн Христийн тухай Хаан Ноагийн ёс бус санваартнуудад заадаг байв, **Моз.** 12–16. Ахмад Алма итгэж мөн түүний үгсийг бичдэг байлаа, **Моз.** 17:2–4. Хаан Ноагаар үхэлд шатаагдсан бөлгөө, **Моз.** 17:20.

АБРАМ. Абрахамыг *үз*

АБРАХАМ. Абрахамын Гэрээг *мөн үз*

Терагийн хөвгүүн, Халдеин Урт төржээ (Эхл. 11:26, 31; 17:5). Их Эзэн түүнтэй мөнхийн гэрээнүүдийг байгуулсан Их Эзэний нэгэн бошиглогч, тэдгээрээр дамжин дэлхийн бүх үндэстнүүд адислагддаг. Абрахам эхлээд Абрам нэртэй байв.

Терагийн нас нөгчсөн Харан уруу дүрвэжээ, **Эхл.** 11:31–32 (Абр. 2:1–5). Канаан уруу аялж мөн бурханлиг гэрээг хүлээн авахаар Бурханаар дуудагджээ, **Эхл.** 12:1–8 (Абр. 2:4, 15–17). Египет уруу аялав, **Эхл.** 12:9–20 (Абр. 2:21–25). Хебронд суурьшив, **Эхл.** 13:18. Лотыг аврав, **Эхл.** 14:1–16. Мелкизедектэй уулзжээ, **Эхл.** 14:18–20. Хейгар түүний хүү Ишмаелыг төрүүлэв, **Эхл.** 16:15–16. Түүний нэр Абрахам болж өөрчлөгдөв, **Эхл.** 17:5. Их Эзэн Абрахам Сара хоёрт, тэд хүүтэй болно хэмээн хэлжээ, **Эхл.** 17:15–22; 18:1–14. Сара түүний хүү Исаакийг төрүүлэв, **Эхл.** 21:2–3. Исаакийг тахилд өргөхөөр зарлигдуулав, **Эхл.** 22:1–18, Сара нас нөгчиж мөн оршуулагдав, **Эхл.** 23:1–2, 19. Абрахам нас нөгчиж мөн оршуулагдав, **Эхл.** 25:8–10. Абрахам Исаакийг тахилд өргөхөд бэлэн байсан нь Бурхан болон түүний Төрсөн Ганц Хүүтэй адил төстэй байлаа, **Иаков** 4:5. Мелкизедект аравны нэгийг төлдөг байв, **Алма** 13:15. Христийн ирэлтийг угтан харж мөн гэрчилж байв, **Хил.** 8:16–17. Мелкизедекээс санваар хүлээн авчээ, **С ба Г** 84:14. Итгэлтнүүд Абрахамын үр удам болдог, **С ба Г** 84:33–34 (Гал. 3:27–29). Бүх зүйлийг илчлэлтээр хүлээн авчээ, **С ба Г** 132:29. Өөрийн өргөмжлөлийг хүлээн авсан бөлгөө, **С ба Г** 132:29. Эцгүүдийн адислалын тул мөн санваарт томилогдохын төлөө эрэлхийлдэг байв, **Абр.** 1:1–4. Халдеин хуурамч санваартнуудаар мөрдөгдөн хавчигдаж байв, **Абр.** 1:5–15. Их Эзэнээр аврагдав, **Абр.** 1:16–20. Нар, сар, мөн оддын талаар мэдэж авав, **Абр.** 3:1–14. Дэлхийн

өмнөх амьдрал хийгээд Бүтээлтийн талаар мэдэж авав, **Абр.** 3:22–28.

Абрахамын Ном: Абрахамын бичсэн эртний цэдгүүд 1835 онд Сүмийн эзэмшилд иржээ. Египетэд агуйн булшнуудад Антония Леболо цэдгүүд хийгээд зарим занданшуулсан цогцсуудыг олж, тэдгээрийг Майкл Чандлерт өгчээ. Чандлер 1835 онд тэдгээрийг Нэгдсэн Улсад үзэсгэлэнд тавьж үзүүлжээ. Иосеф Смитийн хэсэг найз нар тэдгээрийг Чандлераас худалдан авч, тэдгээрийг орчуулсан Бошиглогчид өгсөн байна. Эдгээр цэдгүүдийн зарим нь эдүгээ Агуу Үнэт Сувдад орсон билээ.

Бүлэг 1 нь Халдеин Урт ёс бус санваартнууд түүгээр тахил өргөх гэж оролдсоноор Абрахамд тохиолдсон явдлын тухай цэдэглэжээ. Бүлэг 2 нь Канаан уруу хийсэн түүний аяллын тухай өгүүлдэг. Их Эзэн түүн дээр хүрч ирэн түүнтэй гэрээнүүд хийжээ. Бүлэг 3 нь Абрахам орчлон хорвоог харж мөн тэнгэрийн эрхсүүдийн хоорондын харилцан хамаарлын тухай хүртэхүйгээр мэдэрснийг цэдэглэжээ. Бүлэг 4, 5 нь Бүтээлтийн тухай өөр нэгэн шастир юм.

Абрахамын үр удам: Есүс Христийн сайн мэдээний хуулинд хийгээд ёслолуудад дуулгавартай байснаар, Бурханаар Абрахамд өгөгдсөн амлалтууд хийгээд гэрээнүүдийг хүлээн авдаг хүмүүс. Хэрэв тэд Абрахамын шууд удмынх буюу эсвэл тэд сайн мэдээг хүлээн авч мөн баптисм хүртсэнээр түүний гэр бүлд үрчлэгдсэнээр эрэгтэйчүүд бас эмэгтэйчүүд эдгээр адислалуудыг хүлээн авч болно (Гал. 3:26–29; 4:1–7; С ба Г 84:33–34; 103:17; 132:30–32; Абр. 2:9–11). Абрахамын шууд удмынхан дуулгаваргүй байдлаараа адислалуудаа алдаж болно (Ром, 4:13; 9:6–8).

АБРАХАМЫН ГЭРЭЭ. Абрахам,

Гэрээ; Хөвч хөндөх ёслолыг
мөн үз

Абрахам Сайн мэдээг хүлээн авч

мөн дээд санваарт томилогджээ (С ба Г 84:14; Абр. 2:11), мөн тэрээр өргөмжлөлийн гэрээ болох селестиел гэрлэлтэд орсон байна (С ба Г 131:1–4; 132:19, 29). Эдгээр гэрээнүүдийн бүх адислалууд түүний мөнх бус үр удамд өгөгдөх болно хэмээх амлалтыг Абрахам хүлээн авчээ (С ба Г 132:29–31; Абр. 2:6–11). Эдгээр гэрээнүүд хийгээд амлалтууд нь хамтдаа Абрахамын Гэрээ хэмээн нэрлэгддэг. Энэ гэрээний сэргэлт нь эцсийн өдрүүд дэх сайн мэдээний сэргэлт байлаа, учир нь дэлхийн бүх үндэстэн үүгээр дамжин адислагддаг билээ (Гал. 3:8–9, 29; С ба Г 110:12; 124:58; Абр. 2:10–11).

АБРАХАМЫН ҮР УДАМ.

Абрахам—Абрахамын үр
удмыг үз

АВРАГЧ. Есүс Христийг *мөн үз*

Авардаг хүн. Есүс Христ өөрийн цагаатгалаар дамжуулан гэтэлгэл хийгээд авралыг бүх хүн төрөлхтөнд өгчээ. “Аврагч” нь Есүс Христийн нэр бөгөөд цол юм.

ЭЗЭН бол миний гэрэл хийгээд аврал, **Дуул.** 27:1 (Ег. 15:1–2; 2 Сам. 22:2–3). Бибээр Их Эзэн бөгөөд надаас өөр ямар ч аврагч үгүй, **Иса.** 43:11 (С ба Г 76:1). Түүний нэрийг Есүс хэмээн нэрлэ, учир нь тэр өөрийн хүмүүсээ нүглүүдээс нь аврах болно, **Мат.** 1:21. Та нарт энэ өдөр Аврагч Их Эзэн Христ мэндэллээ, **Лук** 2:11. Бурхан дэлхийг үнэхээр хайрласан учир Төрсөн Ганц Хүү хүмүүнийг аврахаар доош бууж ирсэн, **Иохан** 3:16–17. Христээс өөр хүмүүн аврагдаж болох ямар ч нэр үгүй болой, **Үйлс** 4:10–12 (2 Ниф. 25:20; Моз. 3:17; 5:8; С ба Г 18:23; Мозе 6:52). Аврагч, Их Эзэн Есүс Христийг тэнгэрээс бид хардаг, **Филип.** 3:20. Дэлхийн Аврагч болгохоор Эцэг Хүүг илгээсэн юм, **1 Иохан** 4:14. Их Эзэн Мессиа, дэлхийн Аврагчийг төрүүлэх болно, **1 Ниф.** 10:4. Бурханы Хурга бол дэлхийн Аврагч болой, **1 Ниф.** 13:40. Аврагчийн тухай мэд-

лэг бүх үндэстэн, ястан, хэлтэн, мөн хүмүүст түгэх болно, **Моз.** 3:20. Аврал ирж болохын тулд Христ үхэх хэрэгтэй байв, **Хил.** 14:15–16. Аврагчаар дамжих зөвтгөл хийгээд ариусгал нь зөв хийгээд үнэн болой, **С ба Г** 20:30–31. Бибээр Есүс Христ, дэлхийн Аврагч болой, **С ба Г** 43:34. Миний Төрсөн Ганц бол Аврагч болой, **Мосе** 1:6. Хүүд итгэсэн олон нь нүглүүдээ наманчилбал аврагдах болно, **Мосе** 5:15.

АВРАЛ. Ач ивээл; Биеийн үхэл,

Гэтэлгэх, Гэтэлгэгдэгсэд,
Гэтэлгэл; Гэтэлгэлийн
төлөвлөгөө; Есүс Христ;
Өргөмжлөл; Сүнсний үхэл;
Цагаатгал, Цагаатгахыг *мөн үз*

Сүнсний болон биеийн үхлээс аль алинаас нь аврагдах. Бүх хүмүүс Бурханы ач ивээлээр Есүс Христийн үхэл болон амилалтаар дамжуулан биеийн үхлээс аврагдах болно. Хувь хүн бүр тэрчлэн Бурханы ач ивээлээр, Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан сүнсний үхлээс аврагдаж чадна. Энэхүү итгэл нь сайн мэдээний хууль болон ёслолуудад дуулгавартай байснаар, мөн Христэд үйлчилснээр илэрдэг.

Их Эзэн миний гэрэл ба миний аврал, **Дуул.** 27:1. Тэр зөвхөн миний хад мөн миний аврал, **Дуул.** 62:2. Сайн мэдээ бол авралд Бурханы хүч юм, **Ром** 1:16 (С ба Г 68:4). Өөрсдийн авралаа айдсаар биелүүлэгчүн, **Филип.** 2:12. Бурхан чамайг ариусгалаар дамжуулан авралд сонгосон, **2 Тес.** 2:13. Аврал бол чөлөөтэй, **2 Ниф.** 2:4. Авралын бэлгээс илүү агуу бэлэг гэж байхгүй, **С ба Г** 6:13. Есүс Христ бол аврал ирэх цорын ганц нэр болой, **Мосе** 6:52 (Үйлс 4:10–12). Христийн цагаатгалаар бүх хүн төрөлхтөн аврагдах болно гэдэгт бид итгэдэг, **ИТ** 1:3.

Хүүхдийн аврал: Бяцхан хүүхэд болохоос өөрөөр та нар тэнгэрийн хаант улсад орж чадахгүй, **Мат.** 18:3. Бяцхан хүүхдүүд тэрчлэн мөнх

амьдралтай байх болно, **Моз.** 15:25. Бага насны хүүхдийн баптисм нь жигшүүрт хэрэг бөгөөд Цагаатгалын улмаас бяцхан хүүхдүүд Христэд амьд болой, **Моро.** 8:8–24. Бяцхан хүүхдүүд Төрсөн Ганцаар дамжин гэтэлгэгдсэн; Сатан тэднийг уруу татаж чадахгүй, **С ба Г** 29:46–47. Хүүхдүүд найман нас хүрээд сайн мэдээг заалгаж мөн баптисм хүртэх ёстой, **С ба Г** 68:25–28. Есүс Христээр дамжуулан бяцхан хүүхдүүд ариусгагдсан билээ, **С ба Г** 74:7. Хүн дахин гэм буруугүй нялх хүүхдийн түвшинд очих болно, **С ба Г** 93:38. Хариуцлагын наснаас өмнө нас барсан бүх хүүхдүүд селестиел хаант улсад аврагддаг, **С ба Г** 137:10. Хүүхдүүд дэлхийн үүслээс ариун болой, **Мосе** 6:54.

АВРАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.

Гэтэлгэлийн төлөвлөгөөг үз

АГРИЙП. Паулыг *мөн үз*

Шинэ Гэрээнд, I Херод Агрыйпын хүү, түүнчлэн Вернисе, Друсилла хоёрын дүү. Тэрээр Ливан дахь Чалсисын хаан байжээ. Тэрээр төлөөлөгч Паулыг сонсож, бараг Христэд итгэгч болохоор ятгагдсан байв, (Үйлс 25–26; ИС—Т 1:24).

АГУУ ҮНЭТ СУВД. Бага Иосеф

Смит; Канон; Судруудыг *мөн үз*

Дэлхий дээрх Бурханы хаант улс “агуу үнэт сувд”-тай зүйрлэгджээ (Мат. 13:45–46).

Түүнчлэн Агуу Үнэт Сувд бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн жишиг бүтээлүүд хэмээн нэрлэгддэг судрын дөрвөн боть номны нэг юм. Агуу Үнэт Сувдын анхны хэвлэл нь 1851 онд гарсан бөгөөд эдүгээ Сургаал ба Гэрээнд байдаг зарим материалыг агуулж байжээ. 1902 оноос хойших хэвлэлүүд нь (1) Мосегийн Ном хэмээн нэрлэгддэг. Эхлэлийн Иосеф Смитээр орчуулагдсан хэсгүүд, түүнчлэн Иосеф Смит-Матай хэмээн нэрлэгддэг, Матай 24; (2) Абрахамын Ном хэмээн

нэрлэгддэг, 1835 онд түүний олж авсан үйсэн дээрх египет бичгийн, Иосеф Смитийн орчуулга; (3) Иосеф Смит—Түүх хэмээн нэрлэгддэг, 1838 онд түүний бичсэн Сүмийн тухайд холбогдох Иосеф Смитийн түүхийн хэсэг; (4) итгэл хийгээд сургаалын тунхаг болох Итгэлийн арван гурван тунхгийг агуулдаг.

АГУУ ХИЙГЭЭД ЖИГШҮҮРТ

СҮМ. Чөтгөр—Чөтгөрийн сүмийг үз

АГУУЛАХ. Халамжийг мөн үз

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн өргөлүүдийг бишоп хүлээн авч, итгэлтэйгээр хадгалж, мөн ядууст тарааж өгөх газар. Агуулах бүр нөхцөл байдал шаардсанаас хамаарч, том жижиг байдаг. Итгэлтэй Гэгээнтнүүд авьяас билиг, ур чадвар, эд материал хийгээд санхүүгийн тусламжийг гачигдалтай үед нь ядууст анхаарал халамж тавихын тулд бишопт хандивладаг. Тийм учраас, агуулахад боломжтой үйлчлэлүүд, мөнгө, хоол хүнс буюу бусад эд зүйлс байдаг. Бишоп агуулахын төлөөний хүн бөгөөд эд зүйлс болон үйлчлэлийг хэрэгцээний дагуу Их Эзэний Сүнсний удирдамжаар хуваарилдаг (С ба Г 42:29–36; 82:14–19).

Долоон жилийн өлсгөлөнгийн эсрэг тэд агуулахад хүнсээ цуглуулаг, **Эхл.** 41:34–36, 46–57. Агуулахад бүх аравны нэгээ авч ир, **Малах.** 3:10 (3 Ниф. 24:10). Бишоп энэ Сүмд агуулахыг томилог, **С ба Г** 51:13. Илүүдэл хүнсийг миний агуулахад өгөх ёстой, **С ба Г** 70:7–8. Гэгээнтнүүд агуулах зохион байгуулж бий болгох ёстой, **С ба Г** 78:1–4. Хэрэв эцэг эхэд нь байхгүй бол хүүхдүүд Их Эзэний агуулахаас нэхэх хэрэгтэй, **С ба Г** 83:5.

АДАМ. Адам Ева хоёрын Уналт; Адам-ондай-Ахман; Ева, Еден; Михаилйг; Тэргүүн тэнгэр элч мөн үз

Дэлхий дээр бүтээгдсэн анхны хүн.

Адам бол дэлхий дээрх хүмүүн төрөлхтний эцэг бөгөөд патриарх болой. Еденийн Цэцэрлэг дэх түүний зөрчил нь (Эхл 3; С ба Г 29:40–42; Мосе 4) түүнийг “уналтад” хүргэж, мөн зуурдын болгон, энэ дэлхий дээр хүн төрөлхтөн өсч хөгжихийн тулд зайлшгүй шаардлагатай алхам болсон буюу (2 Ниф. 2:14–29; Алма 12:21–26). Тийм учраас бидний мөнхийн өсөлт хөгжилтийг боломжтой болгоход гүйцэтгэсэн үүргийнхээ төлөө Адам, Ева хоёр хүндэтгэл хүлээх нь зүй ёсны бөлгөө. Адам нь түүнчлэн Эртний Өдөр болон Михаил гэгддэг болой (Дан 7; С ба Г 27:11; 107:53–54; 116; 138:38). Тэрбээр тэргүүн тэнгэр элч бөгөөд хүмүүний гэр бүлийн патриархын хувьд Есүс Христийн хоёр дахь ирэлтэд бэлтгэхийн тулд дэлхийд дахин ирэх болно (С ба Г 29:26).

Бурхан хүнийг өөрийнхөө дүр төрхөөр бүтээжээ, **Эхл.** 1:26–28 (Мосе 2:26–28; Абр. 4:26–28). Бүх зүйлийн дээрх ноёрхлыг Бурхан хүнд өгч мөн өсөн үржиж, мөн дэлхийг дүүргэхийг түүнд зарлиглажээ, **Эхл.** 1:28–31 (Мосе 2:28–31; Абр. 4:28–31). Адам Ева хоёрыг Бурхан Еденийн Цэцэрлэгт байрлуулж мөн сайн ба муугийн мэдлэгийн модноос идэхийг тэдэнд хоригложээ, **Эхл.** 2:7–9, 15–17 (Мосе 3:7–9, 15–17; Абр. 5:7–13). Амьд болгоныг Адам нэрлэв, **Эхл.** 2:19–20 (Мосе 3:19–20; Абр. 5:20–21). Адам Ева хоёрыг Бурхан гэрлүүлжээ, **Эхл.** 2:18–25 (Мосе 3:18–25; Абр. 5:14–21). Адам Ева хоёр Сатанаар уруу татагдаж, хориглогдсон жимснээс хүртэж, мөн Еденийн Цэцэрлэгээс зайлуулагджээ, **Эхл.** 3 (Мосе 4) Адам нас барахдаа 930 настай байв, **Эхл.** 5:5 (Мосе 6:12). Адам анхны хүн байв, **С ба Г** 84:16. Нас барахынхаа өмнө өөрийн зөв шударга удам угсааг Адам-ондай-Аманд хамтад нь дуудан цуглуулж мөн тэднийг адисалжээ, **С ба Г** 107:53–57. Адам тахил өргөв, **Мосе** 5:4–8. Адам баптисм хүртэж, мөн ариун сүнсийг хүлээн авч, санваарт томилогдов, **Мосе** 6:51–68.

АДАМ ЕВА ХОЁРЫН УНАЛТ.

Адам; Биеийн Үхэл;
Гэтэлгэгдэгсэд, Гэтэлгэх;
Гэтэлгэл; Гэтэлгэлийн
төлөвлөгөө; Ева; Есүс Христ;
Сүнсний, Үхэл; Цагаатгал,
Цагаатгах; Эгэл хүнийг *мөн үз*

Энэ дэлхий дээр хүмүүн төрөлтөн мөнх бус байдлыг олсон үйл явц. Адам Ева хоёр хориглогдсон жимснээс идэж, мөнх бус болсон бөгөөд энэ нь тэднийг нүгэл, үхлийн эрхшээлд оруулжээ. Адам дэлхий дээрх “анхны хүн” болов (Моисе 3:7). Уналт бол адислал бөгөөд Адам Ева хоёр бүх хүмүүн төрөлтөний анхны эцэг эхийн хувьд хүндлэгдэх ёстойг хожмын үеийн илчлэлт тодруулсан билээ.

Уналт бол хүмүүний дэвшилд зайлшгүй шаардлагатай алхам байлаа. Уналт тохиох болно гэдгийг Бурхан мэдэж байсан учраас тэрээр мөнх бус байдлын өмнөх амьдралд Аврагчийг төлөвлөсөн байв. Есүс Христ Адамын уналтын тулд мөн түүнчлэн хүмүүний наманчлалын нөхцөлд хувь хүний нүглүүдийн төлөө цагаатгахаар цаг хугацааны голчид иржээ.

Чи түүнээс идсэн тэр өдөртөө л зайлшгүй үхнэ, **Эхл.** 2:17 (Моисе 3:17). Тэр үүний жимснээс авч, тэгээд идэв, **Эхл.** 3:6 (Моисе 4:12). Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно, **1 Кор.** 15:22. Бүх хүмүүн төрөлтөн төөрөлдсөн бас унасан байдалд байлаа, **1 Ниф.** 10:6. Зам нь хүмүүний уналтаас бэлтгэгддэг, **2 Ниф.** 2:4. Адам, Ева хоёр хориглогдсон жимснээс хүртсэний дараа Едений цэцэрлэгээс зайлуулав, **2 Ниф.** 2:19. Хүмүүн байж болохын тулд Адам унасан юм, **2 Ниф.** 2:15–26. Эгэл хүн Бурханы дайсан бөгөөд Адамын уналтаас тийм байсаар ирсэн билээ, **Моз.** 3:19. Аарон Ламонайн эцэгт уналтын тухай заадаг байв, **Алма** 22:12–14. Цагаатгал хийгдэх ёстой, эс тэгвээс бүх хүмүүн төрөлтөн унаж

мөн төөрөлдөх болно, **Алма** 34:9. Бидний анхны эцэг эх хоёр биеийн хийгээд сүнсний хувьд аль алианаар нь Их Эзэний дэргэдээс таслагдсан байлаа, **Алма** 42:2–15 (Хил. 14:16). Уналтын улмаас бидний төрөлхийн чанар хилэнцэт болсон бөлгөө, **Ифер** 3:2. Эдгээр ариун хуулиудыг зөрчсөнөөр хүмүүн унасан хүмүүн болсон юм, **С ба Г** 20:20 (С ба Г 29:34–44). Чи унасан болохоор чи гэтэлгэгдэх болно, **Моисе** 5:9–12. Зөрчлийн улмаас Уналт ирсэн, **Моисе** 6:59. Хүмүүн өөрсдийн нүглийн төлөө шийтгэгдэх болно, **ИТ.** 1:2.

АДАМ-ОНДАЙ-АМАН, Адамыг

мөн үз

Адам нас барахаасаа гурван жилийн өмнө өөрийн зөв шударга үр удмыг тэрээр адислав, (С ба Г 107:53–56) мөн Хоёр дахь Ирэлтийн цагийн өмнө түүний ирэх газар болой (С ба Г 116).

АДИСЛАГДСАН, АДИСЛАЛ,

АДИСЛАХ. Ач ивээл;

Өвчтөнийг адислах;

Патриархын адислалууд;

Талархал, Талархалтай,

Талархах; Хуулийг *мөн үз*

Хүнд бурханлиг ивээлийг хүртээх. Жинхэнэ үнэн аз жаргал, сайн сайхан байдал хийгээд хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулж буй аливаа зүйл нь адислал юм.

Бүх адислалууд мөнхийн хууль дээр тулгуурладаг (С ба Г 130:20–21). Бурхан өөрийнхөө хүүхдүүдийг амьдралд баяр баясгалан олохыг хүсдэг учраас (2 Ниф. 2:25), тэд зарлигуудад нь дуулгавартай байсны үр дүн болгон (С ба Г 82:10), тэрээр залбирлын хариу болон санваарын ёслол (С ба Г 19:38; 107:65–67), эсвээс ач ивээлээрээ дамжуулан адислалуудыг өгдөг (2 Ниф. 25:23).

Адислагдсан байдлын хамгийн түгээмэл нотолгоо бол Ерөөлүүд юм (Мат. 5:1–12; 3 Ниф. 12:1–12).

Ерөнхий адислал: Би чамайг агуу их үндэстэн болгож, мөн би чамайг

адислах болно, **Эхл.** 12:2–3 (1 Ниф. 15:18; Абр 2:9–11). Адислал нь шударга хүний тэргүүн дээр оршдог, **Сур. үгс** 10:6. Итгэлтэй хүн адислалаар бялах болно, **Сур. үг** 28:20. Их Эзэн тэнгэрийн цонхыг нээж та нарт адислалыг хальтал асгах болно, **Малах.** 3:10 (3 Ниф. 24:10). Ерөөлүүд нь адислалыг амладаг, **Мат.** 5:1–12 (3 Ниф. 12:1–12). Хурганы хуримын зоогонд уригдагсад ерөөлтэй, **Илч.** 19:9. Зөв шударга байгч тэрээр Бурханы ээл хишгийг хүртэнэ, **1 Ниф.** 17:35 (Моз 10:13). Хэрэв та нар анхаарах аваас, би та нарт адислалыг үлдээнэ, **2 Ниф.** 1:28. Би та нарт адилхан адислалыг үлдээнэ, **2 Ниф.** 4:9. Тэрээр та нарыг тэр даруй адисална, **Моз.** 2:24. Их Эзэн өөрт нь найдлага тавих тэдгээрийг адисалж мөн дэгжүүлдэг, **Хил.** 12:1. Миний ажлыг урагш авчрахад тусал, мөн чибээр адислагдах болно, **С ба Г** 6:9. Үргэлж залбир, адислал чинь агуу их байх болно, **С ба Г** 19:38. Баптисм хүрт, мөн чибээр миний Сүнсийг, мөн чи хэзээ ч мэдэхгүй тийм агуу адислалыг хүлээн авах болно, **С ба Г** 39:10. Их зовлон зүдгүүрийн дараа адислалууд ирдэг болой, **С ба Г** 58:4. Хүмүүн дуулгавартай дагадаггүй; бибээр зэмлэдэг мөн тэд адислалыг хүлээн авах нь үгүй, **С ба Г** 58:32. Эцэг та нарт хичнээн агуу адислалуудыг бэлтгэснийг та нар ойлгоогүй байна, **С ба Г** 78:17. Дээд санваартнуудаас ёслолуудыг гүйцэтгэх болон сүм дээрх адислалууд ирдэг, **С ба Г** 107:65–67. Бүх адислалууд баглагдсан хууль байдаг, **С ба Г** 130:20. Миний мутар дахь адислалтай байх бүх хүмүүс хуулийг баримтлах ёстой, **С ба Г** 132:5. Их Эзэнд хайртай хүмүүст адислалууд хадгалагдан үлддэг, **С ба Г** 138:52. Абрахам эцгүүдийн адислалуудыг мөн үүнийг гүйцэтгэх эрхийг эрэлхийлсэн бөлгөө, **Абр.** 1:2. *Хүүхдийн адислал:* Тэрээр тэднийг тэвэрч тэднийг адислав, **Марк** 10:16. Тэрээр бяцхан хүүхдүүдийг нэг нэгээр нь тэвэрч тэднийг адислав, **3 Ниф.** 17:21. Ахлагч нар хүүхдүү-

дийг Есүс Христийн нэрээр адислах ёстой, **С ба Г** 20:70.

АЖИЛ, ҮЙЛС

Хүний сайн буюу муу үйлүүд. Хүн бүр өөрийн ажлуудаар шүүгдэх болно.

Их Эзэн хүмүүнд хийсэн үйлийнх нь хариуг өгнө, **Сур. үгс** 24:12. Тэд та нарын сайн үйлийг харахын тулд та нарын гэрэл хүмүүний өмнө гэрэлтэг, **Мат.** 5:16 (3 Ниф. 12:16). Миний Эцэгийн хүслээр хийдэг тэр нь тэнгэрийн хаант улсад орох болно, **Мат.** 7:21. Итгэл нь ажилгүйгээр үхмэл юм, **Иаков** 2:14–26. Тэд ажлуудаараа шүүгдэх ёстой, **1 Ниф.** 15:32 (Моз. 3:24). Ач ивээлээр л бид аврагдана гэдгийг мэдэх нь, бидний хийж чадах бүхний дараа буюу, **2 Ниф.** 25:23. Тэдэнд сайн үйлүүдээс хэзээ ч үл залхахыг заа, **Алма** 37:34. Хүмүүн өөрсдийн ажлуудын дагуу шүүгдэх нь зайлшгүй шаардлага билээ, **Алма** 41:3. Тэдний ажлуудаар чи тэднийг мэдэх болно, **Моро.** 7:5 (С ба Г 18:38). Их Эзэн бибээр бүх хүмүүнийг тэдний ажлуудаар нь шүүх болно, **С ба Г** 137:9.

АЗ ЖАРГАЛ, АЗ ЖАРГАЛТАЙ.

Баяр хөөрийг үз

АЛАГДАГЧ, АЛЛАГА, АМЬ НАСААРАА ХОХИРОГЧ

Христийг, сайн мэдээг, эсвээс өөрийн зөв шударга итгэл үнэмшил хийгээд зарчмуудыг орхисноос амь насаа өгсөн нь дээр гэж үздэг хүн.

Абелаас Зехариаг хүртэлх бүх зөв шударгыг үйлдэгчдийн цус ёс бусчуудын эсрэг гэрчлэх болно, **Мат.** 23:35 (Лук 11:50). Хэн Христийн төлөө, сайн мэдээний төлөө амиа алдана, тэр хүн түүнийгээ аварна, **Марк** 8:35 (С ба Г 98:13). Тэд Стефан уруу чулуу шидэлж байлаа, **Үйлс** 7:59 (Үйлс 22:20). Хаана гэрээс байна, тэнд гэрээслэгчийн үхэл зайлшгүй өгөгдөх ёстой, **Евр.** 9:16–17. Абинадаг унаж, галаар үхэв, **Моз.** 17:20. Хөрвүүлэгдсэн аммонайхачууд

галд хаягдсан байлаа, **Алма** 14:8–11. Олон нь эдгээр зүйлүүдийг гэрчилсний улмаас алагдсан байлаа, **3 Ниф.** 10:15. Миний зорилгын төлөө амь насаа доош тавьсан тэрээр мөнх амьдралыг олох болно, **С ба Г** 98:13–14. Иосеф Смит, Хайрум Смит хоёр сайн мэдээний сэргээлтгийн төлөө амь насаараа хохирогчид байв, **С ба Г** 135. Иосеф Смит өөрийн гэрчлэлийг цусаараа лацдав, **С ба Г** 136:39.

АЛАХ ЕГҮҮТГЭХ, ХӨНӨӨХ.

Аллага; Үхлийн шийтгэлийг үз

АЛБАДАХ, АЛБАДЛАГА. Ариун Сүнснийг мөн үз

Ямар нэг зүйлийг хийх буюу хийхгүй байхыг, ялангуяа Ариун Сүнсний нөлөөлөл болон хүчээр, эрч хүчтэйгээр шаардах.

Миний доторх сүнс намайг албаддаг, **Иов** 32:18. Христийн хайр биднийг албаддаг, **2 Кор.** 5:14. Лебенийг албал зохино хэмээн Сүнсээр албадуулав, **1 Ниф.** 4:10. Сүнс намайг албадаж байна, **Алма** 14:11. Гэрээний дагуу би албадуулагдсан юм, **Алма** 60:34. Аммарон, Ариун Сүнсээр албадуулагдан цэдгүүдийг нуув, **4 Ниф.** 1:48. Сүнсний шаардлагаар яригддаг байх ёстой нь дээрээс ирдэг болой, **С ба Г** 63:64.

АЛБАН ТУНХАГ —1. Гэрлэлт,

Гэрлэх—Олон эхнэр авах ёс;
Вудрафф, Вилфорд;
Тунхаглалыг мөн үз

Сургаал ба Гэрээний сүүлчийн хуудсуудад хэвлэгдсэн байдаг. Албан Тунхаг—1-ийн эхний хэсгийг түүнчлэн Тунхаглал гэдэг. Үүнийг 1890 оны аравдугаар сарын 6-нд ерөнхий чуулган дээр Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф боловсруулж, Сүмийн гишүүдэд толилуулжээ. Олон эхнэр авах ёсыг Нэгдсэн Улсад хууль бус болгосон янз бүрийн хууль 1862 оноос эхлэн дараачийн хорин таван жилийн туршид гарчээ. Хэрэв Гэгээнтнүүд олон эхнэр авах ёсыг

зогсоохгүй бол юу болохыг Их Эзэн үзэгдэл хийгээд илчлэлтээр Вилфорд Вудраффт үзүүлжээ. Тунхаглал нь олон эхнэр авах ёс үүнээс хойш мөрдөгдөхгүйг албан ёсоор зарлажээ.

АЛБАН ТУНХАГ —2. Кимбалл, Спенсер В; Санваарыг мөн үз

Бурханы санваарыг хүртсэн хүний талаарх сургаалын тодорхойлолт, эдүгээ Сургаал ба Гэрээний сүүлчийн хуудсуудад хэвлэгджээ. Санваарыг сүмийн бүх зохистой эрэгтэй гишүүдэд хүртээх ёстойг Их Эзэн 1978 оны зургадугаар сарын эхээр Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалд илэрхийлжээ. Энэ нь үндэс угсаа хийгээд арьсны өнгөнөөс үл хамааран, зохистой бүх эрэгтэй гишүүдэд санваарыг мөн түүнчлэн ариун сүмийн адислалуудыг зохистой бүх гишүүдэд боломжтой болгожээ. 1978 оны есдүгээр сарын 30-нд энэхүү тунхгийг Сүмийн ерөнхий чуулганд толилуулж мөн санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрсөн байна.

АЛБАН ТУШААЛ, АЛБАН ТУШААЛТАН. Санваар;

Томилолт, Томилохыг мөн үз

Эрх мэдэл бүхий албан тушаал буюу байгууллага дахь үүрэг хариуцлага, судруудад ихэвчлэн санваарын эрх мэдлийн албан тушаалыг илэрхийлэхэд хэрэглэдэг; тэрчлэн уг албан тушаалд, эсвэл тэрхүү албан тушаалыг хашиж байгаа хүнд холбогдох үүрэг хариуцлагуудыг зааж болдог.

Бүх гишүүд адил албан тушаалтай байдаггүй, **Ром** 12:4. Бид Их Эзэнд алба өргөдөг байв, **Иаков** 1:19. Мелкизедек дээд санваарын албыг хүлээн авав, **Алма** 13:18. Хүмүүнийг наманчлалд дуудах нь тэнгэр элчүүдийн тохинууллын алба юм, **Моро.** 7:31. Сүмийн санал хураалтгүйгээр энэ Сүмийн аливаа албан тушаалуудад ямар ч хүн томилогддоггүй, **С ба Г** 20:65. Хүн бүр өөрийнхөө албан тушаалд зогсож, **С ба Г** 84:109. Эдгээр хоёр санваарт томилогдог-

дын дундаас ерөнхийлөгчид, тэргүүлэх ажилтнууд, томилогддог, **С ба Г 107:21**. Санваартны чуулгуудын албан тушаал дээр тэргүүлэх тэдний үүргүүд дүрслэгдэв, **С ба Г 107:85–98**. Хүн бүр үүргээ сурч, мөн томилогдсон албан тушаалдаа үйлдэг, **С ба Г 107:99–100**. Би та нарт миний санваарт хамаардаг албан тушаалуудыг өгч байна, **С ба Г 124:1**

АЛДАГДСАН ОВГУУД.

Израил—Израилын алдагдсан арван овгийг үз

АЛДАГДСАН СУДРЫН

НОМНУУД. Судрууд—
Алдагдсан судруудыг үз

АЛДАР СУУ. Алдар суугийн зэргүүд; Гэрэл, Христийн гэрэл; Үнэнийг мөн үз

Судруудад алдар сууг Бурханы гэрэл ба үнэн гэсэн нь олонтаа тохиолддог. Үүнийг түүнчлэн магтаал буюу хүндэтгэл мөн мөнх амьдралын тодорхой нөхцөл буюу Бурханы алдар сууд хамааруулсан байдаг.

Түмний Эээн ариун; бүх л дэлхий Түүний алдар суугаар дүүрэн билээ, **Иса. 6:3** (2 Ниф. 16:3). Бид ижил дүрээр алдар суугаас алдар сууд өрчлөгддөг, **2 Кор. 3:18**. Тэр намайг өөртэйгөө хамт алдар сууд оршихоор өргөх болно, **Алма 36:28**. Амилуулалтад хүлээн авагддаг алдар суунууд зөв шударга байдлын дагуу өөр өөр байх болно, **С ба Г 76:50–119**. Бурханы алдар суу бол оюун билиг бөлгөө, **С ба Г 93:36**. Бурханы алдар суу бол хүмүүний үхэшгүй байдал ба мөнх амьдралыг тохиолгохоор авчрах явдал мөн, **Моце 1:39**. Гялалзсан өнгө хийгээд алдар суу нь бүхий л дүрслэлээс давсан Хоёр Хүнийг би харав, **ИС—Т 1:17**.

АЛДАР СУУГИЙН

ЗЭРЭГЛЭЛҮҮД. Селестиел алдар суу; Теллестиел алдар суу; Террестриел алдар сууг мөн үз

Тэнгэр дэх өөр өөр хаант улсууд. Эцсийн шүүлтээр Мөхлийн хөв-

гүүдээс бусад хүн бүр аль нэг хаант улсын алдар суунд мөнхөд амьдрах газарт томилогдох болно.

Есүс хэлэхдээ, миний Эцэгийн өргөөнд олон харш бий гэв, **Иохан 14:2** (Ифер 12:32). Нарны алдар өөр, сарны алдар өөр, одны алдар өөр байдаг, **1 Кор. 15:40–41**. Паул гурав дахь тэнгэрт аваачигджээ, **2 Кор. 12:2**. Тэр нь алдар суугүй мөн үүрдийн шийтгэлийн газар болой, **С ба Г 76:30–38, 43–45**. Тэнд алдар суугийн гурван зэрэглэл байдаг, **С ба Г 76:50–113; 88:20–32**.

АЛЛАГА. Каин; Үхлийн шийтгэлийг мөн үз

Хүнийг хууль бусаар болон санаатайгаар алах. Аллага бол нэн эрт үеэс зэмлэгдсээр ирсэн нүгэл мөн (Эхл. 4:1–12; Моце 5:18–41).

Хэн хүний цусыг урсгана, түүний цусыг хүн урсгана, **Эхл. 9:6** (ИСО, Эхл. 9:12–13; Ег. 21:12; Алма 34:12). Чи хүн бүү ал, **Ег. 20:13** (Дэд хууль 5:17; Мат. 5:21–22; Моз. 13:21; С ба Г 59:6). Чи хүн бүү ал хэмээн Есүс хэлэв, **Мат. 19:18**. Алуурчдад ноогдох хувь нь хоёр дахь үхэл, **Илч. 21:8**. Та нар зүрх сэтгэлдээ алуурчид бөлгөө, **1 Ниф. 17:44**. Санаатайгаар егүүтгэх тэр алуурчинд халаг, **2 Ниф. 9:35**. Их Эээн Бурхан хүмүүн нь алах ёсон үгүй хэмээн зарлигласан билээ, **2 Ниф. 26:32**. Аллага бол Их Эзэнд жигшүүрт хэрэг мөн, **Алма 39:5–6**. Хүн алдаг түүнд өршөөл үгүй, **С ба Г 42:18**. Хүн алсан хэн ч гэсэн, уг нутгийн хуулинд шилжүүлэн өгөгддөг байх ёстой, **С ба Г 42:79**.

АЛМА, АЛМАГИЙН ХҮҮ.

Ахмад Алма; Амюлек; Мозаягийн хөвгүүдийг мөн үз

Мормоны Номонд, Нифай үндэстний анхны ерөнхий шүүгч бөгөөд бошиглогч. Бага насандаа тэрээр Сүмийг устгахыг эрэлхийлж байжээ (Моз. 27:8–10). Хэдий тийм ч, тэнгэр элч түүнд үзэгдэж, тэрээр сайн мэдээнд хөрвүүлэгджээ (Моз. 27:8–24; Алма 36:6–27). Хожим нь тэрээр

хүмүүст заахын тулд ерөнхий шүүгчийн албан тушаалаасаа татгалзжээ (Алма 4:11–20).

Алмагийн Ном: Бошиглогчид Алмагийн хүү Алма болон түүний хүү Хиламаны цэдгүүдийн хураангуйлыг агуулсан Мормоны Номон доторх тусдаа нэг ном. Номонд мээ 91–52 онд болсон үйл явдлыг дүрсэлжээ. Ном нь 63 бүлэгтэй. Бүлэг 1–4-т нифайчуудын эсрэг Нехор, Амилисай нарыг дагалдагчдын эсэргүүцлийг дүрсэлжээ. Үүний уршгаар өдөөгдсөн дайнууд нь нифайчуудын түүхэн дэх тэр үеийг хүртэлх хамгийн их сүйрүүлэгч хайрууд байв. Бүлэг 5–16 нь Алмагийн эхэн үеийн номлолын аяллуудын шастир, түүний дотор Сайн Хоньчны талаарх түүний номлол хийгээд (Алма 5) мөн Аммонайха хотод Амюлектай хамт хийсэн номлолыг агуулдаг. Бүлэг 17–27 нь Мозаягийн хөвгүүдийн хийгээд Леменчүүдийн дундах тэдний тохиууллын цэдгийг агуулдаг. Бүлэг 28–44 нь Алмагийн хамгийн чухал зарим номлолуудыг агуулдаг. Бүлэг 32-т Алма үгийг үртэй харьцуулсан байдаг; бүлэг 36-д тэрээр хүү Хиламандаа өөрийнхөө хөрвөлтийн тухай ярьжээ. Бүлэг 39–42 нь ёс суртахууны зөрчилд орооцолдсон хүү Кориантондаа өгсөн түүний зөвлөгөөг агуулдаг; энэхүү чухал номлол нь шударга ёс, нигүүлсэл, амилуулалт хийгээд Цагаатгалыг тайлбарладаг. Бүлэг 45–63-т тэр үеийн нифайчуудын дайн болон Хаготын удирдлаган доорх дүрвэлтүүдийг дүрсэлдэг. Ахмад Моронай, Тианкум болон Лихай мэтийн агуу удирдагчид өөрсдийн эрэлхэг зориг хийгээд цагаа олсон үйл ажиллагаагаар дамжуулан нифайчуудыг хадгалан үлдээхэд тусалжээ.

АЛТАН ЯЛТСУУД. Мормоны Ном; Ялтсуудыг *мөн үз*

Алтан ялтсууд дээр бичигдсэн цэдэг. Уг цэдэг нь Америк тив дэх хоёр агуу соёл иргэншлийн түүхийг

өгүүлдэг. Эдгээр ялтсуудын нэг хэсгийг Иосеф Смит орчуулж хэвлүүлсэн билээ. Энэхүү орчуулгыг Мормоны Ном гэдэг (Дэлгэрэнгүй мэдээллийг Мормоны Номны өмнөх Удиртгал болон Бошиглогч Иосеф Смитийн гэрчлэлээс үз).

АЛХАХ, БУРХАНТАЙ ХАМТ

АЛХАХ. Дуулгавартай, Дуулгавартай байдал; Дуулгавартай дагах; Зам; Зөв шударга, Зөв шударга ёсыг *мөн үз*

Бурханы сургаалуудтай нийцсэн байж, Бурхан өөрийн хүмүүсийг амьдрахыг хүсдэг тэр байдлаар амьдрах; Ариун Сүнсний өдөөлтөд дуулгавартай байж, хүлээн авдаг байх.

Тэд Миний хууль дотор алхах нь уу үгүй юу гэдгийг би сорих болно, **Ег.** 16:4. Тэрээр шулуун шударгаар явагсдаас ямар ч сайн юмыг нуун дарагдуулдаггүй, **Дуул.** 84:11. Миний дүрэм дотор явж, миний ёслолуудыг сахидаг тэд миний хүмүүс байх болно, **Езек.** 11:20–21 (Дэд хууль 8:6). Чи Бурхантай даруухнаар алхахаас өөр юуг Их Эзэн чамаас шаардах билээ? **Мика** 6:8 (С ба Г 11:12). Бурхан гэрэл дотор байдгийн адил гэрэл дотор алх, **1 Иох.** 1:7 (2 Иохан 1:6; 4 Ниф. 1:12; 3 Иохан 1:4). Амьдрал уруу хөтөлдөг шулуун замаар алх, **2 Ниф.** 33:9. Бенжамин хаан цэвэр ухамсартайгаар Бурханы өмнө алхдаг байв, **Моз.** 2:27. Та нарын үүрэг бол Бурханы ариун жаягийн дагуу алхах болой, **Алма** 7:22. Сүмийн гишүүд бурханлиг алхаа болон яриаг үзүүлэх ёстой, **С ба Г** 20:69. Бошиглогчдод анхаарлаа хандуулж Их Эзэний өмнө бүх ариунаар алхагтун, **С ба Г** 21:4. Залбирах хийгээд Их Эзэний өмнө цэх шулуун алхахыг хүүхдүүддээ сурга, **С ба Г** 68:28. Надтай үлд, мөн би чамтай хамт буюу; тиймийн тул надтай хамт алх, **Мосе** 6:34.

АЛЬФА БА ОМЕГА. Есүс Христийг *мөн үз*

Альфа бол грек хэлний эхний, Оме-

га нь сүүлчийн үсэг юм. Түүнчлэн Христ бол бүх бүтээлтийн эхлэл ба төгсгөл хэмээн харуулсан бэлэгдэл болж хэрэглэгддэг, Есүс Христэд өгсөн нэр билээ (Илч 1:8; С ба Г 19:1).

АМАЛИКАЙЧУУД (МОРМОНЫ НОМ)

Нифайчуудын эсрэг леменчүүдийг дайнд удирдсан хэсэг урвагч нифайчууд (Алма 21–24, 43).

АМАЛИКЧУУД (ХУУЧИН ГЭРЭЭ)

Араб болон Газрын дундад тэнгисийн хоорондох Параны цөлд амьдардаг байсан араб овог. Мосегийн үеэс (Ег. 17:8) Саул болон Давидын үеийг хүртэл еврейчүүдтэй байнга дайтдаг байжээ (1 Сам. 15; 27:8; 30; 2 Сам. 8:11–12).

АМАЛИКАЯ

Мормоны Номонд, леменчүүдийн дунд хүчтэй болж тэднийг нифайчуудын эсрэг удирдсан нифай үндэстэн урвагч (Алма 46–51).

АМАР АМГАЛАНГ ТОГТООГЧ.

Амар амгаланг *мөн үз*

Амар амгаланг тогтоодог буюу хөхиүлэн дэмждэг хүн (Мат. 5:9; 3 Ниф. 12:9). Сайн мэдээг тунхагладаг хүн бас амар амгаланг тогтоогч байж болно (Моз. 15:11–18).

АМАР АМГАЛАН, ЭНХ

ТАЙВАН. Амар амгаланг тогтоогч; Амралт, Мянган жилийг *мөн үз*

Судруудад амар амгалан гэдэг нь нэг бол зөрчилдөөн болон үймээн самуунаас чөлөөтэй байх, эсвээс итгэлтэй Гэгээнтнүүдэд Бурханы өгдөг Сүнснээс үүдэлтэй дотоод амар тайван байдал болон ая тух гэсэн утгатай байдаг.

Зөрчил болон үймээн самуунаас чөлөөтэй байх нь: Тэрээр дайныг зогсоодог, Дуул. 46:9. Дахин хэзээ ч тэд дайтахад суралцахгүй, Иса. 2:4. Бүх хүмүүнтэй амар амгалан амьдар;

өөрсдөөсөө өс бүү ав, Ром 12:18–21. Уг нутагт амар амгалан үргэлжилсээр байв, 4 Ниф. 1:4; 15–20. Дайнаас татгалзаж мөн энх амгаланг тунхагла, С ба Г 98:16. Энх амгалангийн тугийг өргөгтүн, С ба Г 105:39.

Дуулгавартнуудад Бурханаас ирдэг амар амгалан: Аврагч нь Энхийн Жонон хэмээн дуудагдах болно, Иса. 9:6. Хилэнцэт амар тайван байхгүй, Иса. 48:22. Олон тооны тэнгэрлэг дайчид үзэгдэж, Бурханыг магтан, дээр өндөрт алдар нь Бурханд байх болтугай, доор газарт амар тайван нь байх болтугай, Лук 2:13–14. Амар амгаланг би та нарт үлдээнэ, Иохан 14:27. Бурханы амар амгалан нь бүх ойлголтыг хамардаг, Филип. 4:7. Хаан Бенжамины хүмүүс ухамсрын амар амгаланг хүлээн авав, Моз. 4:3. Энх амгаланг тунхаглах тэдний хөл уулсын дээр хичнээн үзэсгэлэн төгөлдөр билээ? Моз. 15:14–18 (Иса. 52:7). Алма Их Эзэнд залбиран гуйж мөн амар амгаланг олов, Алма 38:8. Зөв шударга тэдний сүнс нь энх амгалангийн байдалд хүлээн авагдсан байв, Алма 40:12. Энэ асуудлын талаар чиний оюунд амар амгаланг би яриагүй бил үү? С ба Г 6:23. Миний Сүнсний номхон дөлгөөн байдалд алхагтун, мөн надаар дамжин амар амгалан чамд байх болно, С ба Г 19:23. Зөв шударга ёсны ажлуудыг хийдэг тэрээр амар амгаланг хүлээн авах болно, С ба Г 59:23. Төгс чанар хийгээд амар амгалангийн үүрэг болох энэрлийн үүргээр өөрсдийгөө хувцаслагтун, С ба Г 88:125. Хүү минь бодгальд чинь амар амгалан байг, С ба Г 121:7. Агуу амар амгаланг олоод би эцгүүдийн адислалуудын төлөө эрэлхийлэв, Абр. 1:2.

АМЕН. Залбирлыг *мөн үз*

“Ийм байх болтугай”, “ийм байг” гэсэн утгатай. Чин сэтгэлээсээ хийгээд гүн хүндэтгэлтэйгээр хүлээн авч, зөвшөөрч байгааг, эсвээс чин үнэнч байгаагаа харуулахын тулд Амен гэж хэлдэг (Дэд хууль 27:14–26), (Хаад. дээд 1:36). Өнөөдөр зал-

бирлууд, гэрчлэлүүд мөн үг хэлсний эцэст хүлээн авч, мөн зөвшөөрч байгаагаа харуулахын тулд залбирлыг болон захиас үгсийг сонссон бүхэнд дуулдахаар *амен* хэмээн хэлдэг.

Хуучин Гэрээний үед хүн тангараг өргөхдөө *амен* хэмээн хэлдэг байжээ (Шаст. дээд 16:7, 35–36; Нех. 5:13; 8:2–6). “Итгэлтэй хийгээд үнэнч гэрч, Амен” хэмээн Христийг нэрлэдэг (Илч 3:14). Бошиглогчдын Сургуульд *амен* нь түүнчлэн гэрээний тэмдэг болон үйлчилдэг байжээ (С ба Г 88:133–35).

АМИЛУУЛАЛТ. Бие; Биеийн үхэл; Есүс Христ; Үхэшгүй, Үхэшгүй байдал; Цагаатгал; Цагаатгахыг *мөн* үз

Үхлийн дараа сүнсэн бие ястай дахин нэгдэх. Амилуулалтын дараа сүнс бие хоёр дахин хэзээ ч салахгүй, мөн хүн үхэшгүй болох болно. Есүс Христ үхлийг ялсан учраас дэлхий дээр төрсөн хүн болгон амилуулагдах болно (1 Кор. 15:20–22).

Есүс Христ бол энэ дэлхий дээр амилсан анхны хүн юм (Үйлс 26:23; Кол. 1:18; Илч. 1:5). Есүс өөрийн бие бялдраар босч ирсэн бөгөөд түүний булш хоосон байсныг; тэрээр мах ясан биетэй байсныг хүмүүс тэмтэрч үзэн, мөн тэрээр босч ирсэн хэмээн тэнгэр элчүүд хэлсэн тухай Шинэ Гэрээ тод томруунаар өгүүлдэг билээ (Марк 16:1–6; Лук 24:1–12, 36–43; Иохан 20:1–18). Христийн хийгээд бүх хүн төрөлхтний амилуулалт бодитой тухай хожмын үеийн илчлэлт нотолдог (Алма 11:40–45; 40; 3 Ниф. 11:1–17; С ба Г 76; Мосе 7:62).

Бүх хүмүүс нэгэн адил алдар сууд амилуулагдахгүй, (1 Кор. 15:39–42; С ба Г 76:89–98). Мөн түүнчлэн бүгд нэгэн цаг үед амилуулагдахгүй (1 Кор. 15:22–23; Алма 40:8; С ба Г 76:64–65, 85). Христийн амилалтын дараа олон Гэгээнтэн амилуулагдсан билээ (Мат. 27:52). Зөв шударгыг үйлдэгчид ёс бусчуудын өмнө амилуулагдах бөгөөд анхны амилуулалтад босч ирэх болно (1 Тесл.

4:16); Наманчилдаггүй нүгэлтнүүд сүүлчийн амилуулалтад босч ирэх болно (Илч. 20:5–13; С ба Г 76:85).

Энэ бие минь устгагдлаа ч гэсэн, би махан биеэрээ Бурханыг харах болно, **Иов** 19:26 (Мосе 5:10). Би та нарын булшнуудыг нээж, та нарыг булшнуудаас чинь гаргана, **Езек.** 37:12. Булшнууд нээгдэж, олон бие босов, **Мат.** 27:52–53 (3 Ниф. 23:9). Эзэн үнэхээр амилсан байна, **Лук** 24:34. Сүнсэнд та нарын харж байгаа над шиг яс, мах байдаггүй, **Лук** 24:39. Би бол амилалт ба амь мөн, **Иохан** 11:25. Арванхоёр Төлөөлөгч Есүс амилсныг заадаг байв, **Үйлс** 1:21–22 (Үйлс 2:32; 3:15; 4:33). Христэд бүгд амьд болгогдох болно, **1 Кор.** 15:1–22. Нас барагсад Христэд эхлээд амилагдах болно, **1 Тес.** 4:16. Эхний амилуулалтад хувьтай байх тэд ерөөлтэй хийгээд ариун билээ, **Илч.** 20:6. Христ өөрийн амийг өгч мөн нас барагсдын амилуулалтыг тохиолгон авчирч болохын тулд тэрээр үүнийг дахин авсан билээ, **2 Ниф.** 2:8 (Моз. 13:35; 15:20; Алма 33:22; 40:3; Хил. 14:15). Амилуулалтгүйгээр бид Сатаны эрхшээлд байх байсан, **2 Ниф.** 9:6–9. Бүх хүмүүний дээр амилуулалт тохиох болно, **2 Ниф.** 9:22. Абинадай эхний амилуулалтын тухай заадаг байв, **Моз.** 15:21–26. Ёсон бусыг үйлдэгчдийн үхлийн хүлээс алдуурхаас бусдаар, гэтэлгэл хийгдээгүй мэтээр үлдэнэ, **Алма** 11:41–45. Үхэл ба амилалтын хоорондох бодгалиудын байдлыг Алма тайлбарлав, **Алма** 40:6, 11–24. Их Эзэний ирэлтээр Христэд нас нөгчсөн үхэгсэд урагш гарч ирэх болно, **С ба Г** 29:13 (С ба Г 45:45–46; 88:97–98; 133:56). Алдар суут амилуулалтад найдваргүй тэдний төлөө уйлагтун, **С ба Г** 42:45. Хуулийг мэддэггүй байсан тэд анхны амилуулалтад багтах болно, **С ба Г** 45:54. Тэд нас барагсдаас босч ирэн, дараа нь үхэхгүй байх болно, **С ба Г** 63:49. Нас барагсдаас амилуулагдах нь бодгалиудын гэтэлгэл мөн, **С ба Г** 88:14–16. Салшгүй холбогдсон сүнс

ба элемент бүрэн баяслыг хүлээн авдаг, **С ба Г** 93:33. Амилуулагдсан хүмүүс болох тэнгэр элчүүд махан бие хийгээд ястай, **С ба Г** 129:1. Энэ амьдралд бид оюун билгийн ямар ч хөгжилд хүрлээ гэсэн энэ нь амилуулалтад бидэнтэй хамт сэргээгдэх болно, **С ба Г** 130:18–19.

АМЛАГДСАН НУТАГ

Өөрийн итгэлтэй дагалдагчдад, мөн тэрчлэн олонтаа тэдний үр удмынханд өв болгон Их Эзэний амласан нутгууд. Амлагдсан нутаг олон бий. Мормоны Номон дахь амлагдсан нутаг нь Америкийн тухай өгүүлсэн байх нь олонтаа тохиолддог.

Би чиний үр удамд энэ нутгийг өгье, **Эхл.** 12:7 (Абр. 2:19). Канааны газар нутгийг би чамд болон чиний үр удмынханд өгөх болно, **Эхл.** 17:8 (Эхл. 28:13). Мосе Канаан дахь Израйлын газар нутгийн хил хязгаарыг тогтоов, **Тоол.** 34:1–12 (Тоол. 27:12). Та нар амлагдсан нутаг тийш удирдагдах болно, **1 Ниф.** 2:20 (1 Ниф. 5:5). Зөв шударгыг үйлдэгчдийг Их Эзэн эрхэм сайхан нутаг тийш удирдах болно, **1 Ниф.** 17:38. Хэрэв Лихайн үр удам Бурханы зарлигуудыг сахих аваас, тэд амилуулалтын нутагт дэвжин хөгжих болно, **2 Ниф.** 1:5–9. Израил өөрсдийн амлалтын нутагт эргэж ирэх болно, **2 Ниф.** 24:1–2 (Иса. 14:1–2). Энэхүү амлагдсан нутгийг эзэмших ямар ч үндэстэн Бурханд үйлчлэх ёстой, эс бөгөөс тэд арчигдах болно, **Ифер** 2:9–12. Энэ бол амлалтын нутаг, мөн Сион хотын газар бөлгөө, **С ба Г** 57:2. Иуда Абрахамын нутгуудад эргэж ирэх нь эхэлж болох буюу, **С ба Г** 109:64. Шинэ Иерусалим Америк тивд баригдах болно, **ИТ** 1:10.

АМЛАЛТЫН АРИУН СҮНС.

Ариун Сүнсийг *мөн үз*

Ариун Сүнс бол Амлалтын Ариун Сүнс юм (Үйлс 2:33). Тэрээр Бурханд хүлээн зөвшөөрөгдөхүйц зөв шударга үйлүүд, ёслолууд хийгээд гэрээнүүдийг баталдаг. Аврагч ёслолууд

зохих ёсоор гүйцэтгэгдсэн хийгээд тэдгээртэй холбоотой гэрээнүүд сахигдаж байгааг Амлалтын Ариун Сүнс Эцэгт гэрчилдэг.

Амлалтын Ариун Сүнсээр лацдагдсан тэд Эцэгт байгаа бүхнийг хүлээн авдаг, **С ба Г** 76:51–60 (Еф. 1:13–14). Бүх гэрээнүүд болон гүйцэтгэлүүд энэ амьдралын дараа хүчин төгөлдөр байхын тулд Амлалтын Ариун Сүнсээр лацдагдах ёстой, **С ба Г** 132:7, 18–19, 26.

АМЛИСАЙ, АМЛИСАЙЧУУД

Мормоны Номонд, ерөнхий шүүгчдийн засаглалын үед хаантай болохыг хүссэн хэсэг нифайчуудыг удирдсан хүн. Тэдгээр нифайчуудыг амлисайчууд гэдэг байсан бөгөөд Бурханы эсрэг илт эсэргүүцэний улмаас тэд зүхэгджээ (Алма 2–3).

АММОН, ЗАРАХЕМЛАГИЙН

УДАМ. Лимхайг *мөн үз*

Мормоны Номонд, Зарахемлагаас Лихай-Нифайн нутаг хүртэл гандуулын хэсгийг удирдсан хүчирхэг, агуу хүн (Моз. 7:1–16). Түүгээр эртний цэдгүүд үзүүлэгдэж үзмэрч хэн болохыг тайлбарлав (Моз. 8:5–18). Дараа нь тэр Хаан Лимхай болон түүний хүмүүсийг леменчүүдээс чөлөөлж тэднийг Зарахемлад буцаан авчрахад тусалжээ (Моз. 22).

АММОН, МОЗАЯГИЙН ХҮҮ.

Антай-Нифай-Лихайчууд;

Бенжамин хүү Мозая;

Мозаягийн хөвгүүдийг *мөн үз*

Мормоны Номын Хаан Мозаягийн хүү. Хичээнгүй зүтгэл нь олон хүнийг Христэд хөрвөхөд тусалсан Аммон номлолд үйлчилжээ.

Сүмийг устгахыг хичээж байсан үл итгэгч нэгэн байв, **Моз.** 27:8–10, 34. Тэнгэр элч түүн дээр болон хамтрагчид дээр нь хүрч иржээ, **Моз.** 27:11. Наманчилж мөн Бурханы үгийг номлож эхлэв, **Моз.** 27:32–28:8. Хаан хэмээн нэрлэгдэхээс татгалзаж мөн оронд нь леменчүүдийн нутаг

уруу явж Бурханы үгийг номлов, **Алма** 17:6–9. Зааврын тул мацаг барин залбирчээ, **Алма** 17:8–11. Хаан Лемонайд хүлэгдэн аваачигдав, **Алма** 17:20–21. Лемонайн сүүргийг хамгаалжээ, **Алма** 17:26–39. Лемонайд номлов, **Алма** 18:1–19:13. Бурханд талархаж баясалдаа дийлдэн байв, **Алма** 19:14. Түүний хөрвөгчид хэзээ ч итгэл алдраагүй юм, **Алма** 23:6. Мянга мянган хүмүүсийг үнэнд авчрах Бурханы мутар дахь зэмсэг байсандаа баясжээ, **Алма** 26:1–8 (**Алма** 26:1–37). Антай-Нифай-Лихайн хүмүүсийг аюулгүй байдал тийш удирдав, **Алма** 27. Ах дүүстэйгээ уулзаж агуу баяслаар дүүрэв, **Алма** 27:16–18.

АМОС

Иудейн хаан Уза болон Израилын хаан Иеробоамын өдрүүдэд ойролцоогоор мээ 792-оос 740 онд бошиглож асан Хуучин Гэрээний бошиглогч.

Амосын ном: Хуучин Гэрээний нэг ном. Амосын бошиглогуудаас олон нь Израил болон түүний хөрш үндэстнүүдийг зөв шударга байдалд буцаж ирэхийг сануулсан байдаг.

Бүлэг 1–5-д Израил болон түүний хөрш үндэстнүүдийг наманчлалд дууджээ. Бүлэг 3 нь Их Эзэн өөрийнхөө нууцуудыг бошиглогчдод илчилдэг хийгээд зөрчлийн улмаас Израил дайснаар устгагдах болно гэдгийг тайлбарладаг. Бүлэг 6–8 нь Ассирийн довтолгооноос олон жилийн өмнөх Израилын уналтыг бошигложээ. Бүлэг 9-д Израил газар нутагтаа сэргээгдэх болно гэдгийг бошиглодог.

АМРАЛТ. Амар амгалан, энх тайван; Хүндэтгэлийн өдрийг мөн үз

Сэтгэлийн түгшүүр хийгээд шаналлаас чөлөөтэй байж амар амгаланг эдлэх. Ийм амралтыг Их Эзэн энэ амьдралын хугацаанд өөрийн итгэлтэй дагалдагчдад амлажээ. Тэрээр

түүнчлэн дараагийн амьдралд ч тэдэнд зориулан амрах газрыг бэлтгэсэн билээ.

Миний оршихуй чамтай хамт явж, би чамд амралт өгнө, **Ег.** 33:14. Хүнд ачаа үүрсэн та бүгд надад ирэгтүн, би та нарт амралт өгөх болно, **Мат.** 11:28–29. Тэд түүний амралтад орж болохын тулд бид хөдөлмөрлөсөн юм, **Иаков** 1:7 (**Евр.** 4:1–11). Наманчилдаг хэн боловч миний амралтанд орох болно, **Алма** 12:34. Цэвэр ариун болгогдож мөн Их Эзэний амралтанд орсон тэд үлэмж агуу олон байв, **Алма** 13:12–16. Диваажин бол амралтын байдал мөн, **Алма** 40:12 (**Алма** 60:13). Миний цусанд тэд өөрсдүүдээ угаасан тэднээс бусад нь юу ч түүний амар амгаланд орохгүй, **3 Ниф.** 27:19. Та нар тэдэнтэй хамт миний Эцэгийн хаант улсад амарч болохын тулд энэ хүмүүст наманчлалыг тунхаглагтун, **С ба Г** 15:6 (**С ба Г** 16:6). Нас барсан тэд өөрсдийн бүхий л хөдөлмөрүүдээс амрах болно, **С ба Г** 59:2 (**Илч.** 14:13). Их Эзэний амралт түүний алдар суугаар дүүрэн билээ, **С ба Г** 84:24.

АМЬ АМЬДРАЛ. Гэрэл, Христийн гэрэл; Мөнх амьдралыг мөн үз

Бурханы хүчээр бий болгогдох боломжтой цаг зуурын хийгээд сүнсний оршин тогтнохуй.

Чамаас өмнө би энэ амьдралын өдөр хийгээд сайн сайхныг бий болгосон, **Дэд хууль** 30:15–20. Та надад амьдралын замыг таниулна, **Дуул.** 16:11. Зөв шударгыг хайдаг хүн амьдралыг олдог, **Сур.** үгс 21:21. Амиа ологч нь түүнийгээ алдах болно; миний төлөө амиа алдсан нь түүнийгээ олох болно, **Мат.** 10:39 (**Мат.** 16:25; **Марк** 8:35; **Лук** 9:24; 17:33). Хүний Хүү хүмүүсийн амийг хөнөөхийн тулд биш, харин тэднийг аврахаар ирсэн юм, **Лук** 9:56. Түүнд амьдрал байсан бөгөөд амьдрал нь хүмүүний гэрэл байлаа, **Иохан** 1:4. Намайг илгээгч

түүнд итгэдэг тэр нь үхлээс өнгөрч амьдралд шилждэг, **Иохан** 5:24. Би бол зам, үнэн, амьдрал билээ, **Иохан** 14:6. Хэрэв бид зөвхөн энэ амьдралд Христэд найдах аваас, бид хамгийн золгүй нь байна, **1 Кор.** 15:19–22. Бурханлиг байдалд эдүгээгийн амьдралын хийгээд ирэх амьдралын амлалт буй, **1 Тим.** 4:8. Бидний хүүхдүүд Христэд байдаг тэрхүү амьдралыг хүсэн хүлээх болно, **2 Ниф.** 25:23–27. Энэ амьдрал бол Бурхантай уулзахаар хүмүүний бэлтгэх үе юм, **Алма** 34:32 (Алма 12:24). Би бол дэлхийн гэрэл бөгөөд амьдрал мөн, **3 Ниф.** 9:18 (Моз. 16:9; **3 Ниф.** 11:11; Ифер 4:12). Итгэлтэй тэд амьд ч байсан, нас барсан байсан ч адислагдсан болой, **С ба Г** 50:5. Бурхан болон Есүс Христийг мэдэх нь мөнх амьдрал мөн, **С ба Г** 132:24. Хүмүүнд үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрах нь миний ажил хийгээд алдар суу бөлгөө, **Мосе** 1:39.

АМЬДРАЛЫН МОД. Еденийг

мөн үз

Еденийн Цэцэрлэг, түүнчлэн Бурханы диваажин дахь мод (Эхл. 2:9; Илч. 2:7). Лихайн зүүдэнд амьдралын мод нь Бурханы хайрыг төлөөлдөг бөгөөд Бурханы бүх бэлгүүдээс хамгийн агуу нь хэмээн тооцогддог (1 Ниф. 8; 11:21–22, 25; 15:36).

Херубууд болон галт илд амьдралын модыг хамгаалдаг, **Эхл.** 3:24 (Алма 12:21–23; 42:2–6). Иохан амьдралын модыг харсан бөгөөд навчнууд нь үндэстнүүдийг эдгээх хүчтэй, **Илч.** 22:2. Лихай амьдралын модыг болгоов, **1 Ниф.** 8:10–35. Нифай эцгийнхээ харсан модыг харав, **1 Ниф.** 11:8–9. Төмөр саваа нь амьдралын мод уруу хөтөлдөг, **1 Ниф.** 11:25 (1 Ниф. 15:22–24). Аймшигт ангал амьдралын модноос салгадаг, **1 Ниф.** 15:28, 36. Хориглогдсон жимс бол амьдралын модны сөрөг зүйл юм, **2 Ниф.** 2:15. Их Эзэнд ир мөн амьдралын модны жимснээс хүрт, **Алма** 5:34, 62. Хэрэв бидний анхны

эцэг эх амьдралын модноос хүртсэн бол, тэд үүрд зовлонд байхсан, **Алма** 12:26. Хэрэв та нар үгийг арчлахгүй аваас, та нар хэзээ ч амьдралын модны жимснээс түүж чадахгүй, **Алма** 32:40. Цэцэрлэгийн дунд Их Эзэн амьдралын модыг тарьсан болой, **Мосе** 3:9 (Абр. 5:9). Бурхан амьдралын модноос идэж мөн мөнх амьдруулахгүйн тулд Адамыг Еденийн цэцэрлэгээс явуулжээ, **Мосе** 4:28–31.

АМЬДРАЛЫН НОМ.

Дурсамжийн номыг мөн үз

Амьдралын ном нь хүний бүх бодол санаа ба үйл ажиллагаа—түүний амьдралын цэдэг гэсэн санааг агуулдаг. Хэдий тийм ч, итгэлтнүүдийн нэрс болон тэдний зөв шударга үйлсийн шастирыг багтаадаг тэнгэрлэг цэдэг хөтлөгддөгийг судрууд бас харуулдаг.

Их Эзэн нүгэлтнүүдийг өөрийнхөө номноос авч хаяна, **Ег.** 32:33. Ялагч нь амьдралын номноос авч хаягдахгүй, **Илч.** 3:5. Өөр нэг ном дэлгээстэй байсан бөгөөд тэр нь амийн ном байв, **Илч.** 20:12 (С ба Г 128:6–7). Зөв шударгыг үйлдэгчдийн нэрс амьдралын номонд бичигдэнэ, **Алма** 5:58. Та нарын залбирлууд ариусгагдагсдын нэрсийн номонд цэдэглэгдсэн болой, **С ба Г** 88:2.

АМЬДРАЛЫН ТАЛХ. Ариун

ёслол; Есүс Христийг мөн үз

Есүс Христ бол Амьдралын талх юм. Ариун ёслолын талх нь Христийн биеийг бэлэгдэн төлөөлдөг.

Би бол амьдралын талх, **Иохан** 6:33–58. Амьдралын талх мөн усыг ид, мөн уу, **Алма** 5:34. Талх бол Христийн биеийг төлөөлдөг, **3 Ниф.** 18:5–7. Талх нь Христийн махан биеийн бэлэгдэл, **С ба Г** 20:40, 77 (Моро 4:1–3).

АМЬДРУУЛАХ. Амилуулалтыг

мөн үз

Амь оруулах, амьдруулах эсвээс хүнийг Бурханы оршихуйд байж чадахаар болгон өөрчлөх.

Бурхан биднийг Христийн хамт амьд болгосон юм, **Еф.** 2:4–5 (Кол. 2:6, 12–13). Христ махан бие дотор үхэж, Сүнсээр амилагдав, **1 Петр** 3:18 (С ба Г 138:7). Сүнсээр амилуулагдахгүй юм бол, хүмүүн Бурханыг харах нь үгүй, **С ба Г** 67:11. Гэтэлгэл нь бүх зүйлийг амилуулдаг түүгээр дамждаг билээ, **С ба Г** 88:16–17. Гэгээнтнүүд амилуулагдаж, мөн Христийг угтахаар дээш аваачигдах болно, **С ба Г** 88:96. Адам доторх хүндээ амьдруулагдав, **Моисе** 6:65.

АМЬД УС. Есүс Христийг *мөн үз*

Есүс Христ болон түүний сургаалуудын бэлэгдэл. Амьдралыг тэтгэхэд ус нэн чухал шаардлагатайн адил Аврагч болон түүний сургаалууд (амьд ус) мөнх амьдралын хувьд туйлын чухал юм.

Та нар авралын худгаас баяр хөөртэйгөөр ус татах болно, **Иса.** 12:3. Тэд амьд усны ундарга болох намайг умартсан юм, **Иере.** 2:13. Миний өгөх тэр уснаас уудаг хэн ч гэсэн, хэзээ ч цангах нь үгүй, **Иохан** 4:6–15. Хэрэв хэн нэгэн хүн цангах аваас тэрээр надад ирж мөн ууг, **Иохан** 7:37. Төмөр бариул нь амьд усны ундарга уруу хөтөлдөг байв, **1 Ниф.** 11:25. Амьдралын уснаас чөлөөтэйгөөр хүртэгтүн, **С ба Г** 10:66. Миний зарлигууд амьд усны худаг байх болно, **С ба Г** 63:23.

АМЮЛЕК. Алмагийн хүү, Алмаг *мөн үз*

Мормоны Номонд Алмагийн хүү Алмагийн номлолын хамтрагч.

Тэнгэр элчээр зочлогдов, **Алма** 8:20; 10:7. Алмаг гэртээ хүлээн авав, **Алма** 8:21–27. Аммонихайн хүмүүст хүчтэйгээр номлов, **Алма** 8:29–32; 10:1–11. Нифай, Лихай, болон Манассегийн удам байв, **Алма** 10:2–3. Үнэнийг гэрчлэв, **Алма** 10:4–11. Хүмүүсийг наманчлалд дуудаж мөн эсэргүүцэгдэв, **Алма** 10:12–32. Зиезромтой тэрсэлдэв, **Алма** 11:20–40. Амилуулалт, шүүлт мөн сэргэлтийг заав, **Алма** 11:41–45. Итгэгчдийг хөнөө-

хийг зогсоохыг хүсчээ, **Алма** 14:9–10. Алматы хамт шоронд хоригдов, **Алма** 14:14–23. Итгэлээр шоронгийн хүлээснээс чөлөөлөгдөв, **Алма** 14:24–29. Пагаатгал, энэрэнгүй байдал, шударга ёсыг гэрчилжээ, **Алма** 34:8–16. Залбирлын тухай заав, **Алма** 34:17–28. Наманчлахаа бүү хойшлуул хэмээн хүмүүсийг зоригжуулав, **Алма** 34:30–41. Алма Амюлек хоёрын итгэл шоронгийн ханыг нурахад хүргэжээ, **Ифер** 12:13.

АНАНИА, ИЕРУСАЛИМЫН

Шинэ Гэрээнд тэр болон түүний эхнэр Сапфира хоёр Их Эзэнд өргөсөн мөнгөнийхөө хэсгийг нууснаар Их Эзэнд худал хэлжээ. Петр тэднийг нүүрэлдүүлэхэд тэд хоёул газарт унан нас баржээ (Үйлс 5:1–11).

АНДРЕЙ

Шинэ Гэрээнд Симон Петрийн ах мөн мөнх бус амьдралынхаа тохиууллын үед Арванхоёр Төлөөлөгчийн нэг байхаар Есүсээр дуудагджээ (Мат. 4:18–19; Марк 1:16–18, 29).

АННА

Шинэ Гэрээнд, ашер овгийн эмэгтэй бошиглогч. Есүсийг төрөх үед тэрээр өндөр настай бэлэвсэн байжээ. Тэрээр нялх Есүсийг ариун сүмд очих үед нь харж, Гэтэлгэгч болохыг нь таньжээ (Лук 2:36–38).

АННАС. Каиафыг *мөн үз*

Шинэ Гэрээнд, Санхедринд их нөлөөтэй байсан хүн. Есүсийг баривчлагдахад түүнийг хамгийн түрүүнд түүн дээр авчиржээ (Иохан 18:13); мөн тэрээр Төлөөлөгчдийг шүүх үйл ажиллагааг удирдах эрхийг авчээ (Үйлс 4:3–6).

АНТАЙ-НИФАЙ-ЛИХАЙЧУУД.

Мозагийн хөвгүүд; Мозагийн хүү, Аммон; Хиламан, түүний хөвгүүдийг *мөн үз*

Мормоны Номонд Мозагийн хөвгүүдээр хөрвүүлэгдсэн леменчүүдэд өгсөн нэр. Хөрвүүлэгдсэнийхээ дараа мөн амьдралынхаа турш

итгэлтэйгээр амьдарсан эдгээр хүмүүс тэрчлэн Аммоны хүмүүс хэмээн дуудагддаг байв (Алма 23:4–7, 16–17; 27:20–27).

Тэд Антай-Нифай-Лихайчууд гэдэг нэрийг авав, **Алма** 23:16–17; 24:1. Тэд цус асгаруулахыг хүлцэж мөн тэд зэвсгүүдээ нуув, **Алма** 24:6–19. Тэдний хүүхдүүд дайнд бэлтгэж Хиламаныг өөрсдийнхөө удирдагч байхаар сонгов, **Алма** 53:16–19; 56–58 (эдгээр хөвгүүдийг мөн 2000 залуу цэрэг гэдгээр нь мэддэг).

АНХААРАХ. Дуулгавартай,
Дуулгавартай байдал,
Дуулгавартай дагах, Чихийг
мөн үз

Их Эзэний дуу хоолой буюу сургаалуудыг сонсож мөн дуулгавартай дагах.

Эзэн өөр шигээ нэгэн эш үзүүлэгчийг гаргаж ирнэ, та нар түүнийг сонсох болно, **Дэд хууль** 18:15. Сонсож дагах нь эр хонины өөхнөөс илүү, **1 Сам.** 15:20–23. Эзэний зарц нар болох эш үзүүлэгчдийг бид сонсоогүй, **Дан.** 9:6. Бошиглогчдын үгсийг сонсдог зөв шударга тэд мөхөх нь үгүй болой, **2 Ниф.** 26:8. Хэрэв та нар сайн хоньчны дуу хоолойг сонсохгүй бол, та нар түүний хонь биш, **Алма** 5:38 (Хил. 7:18). Сонсогтун, Ай, миний сүмийн хүмүүс та нар, **С ба Г** 1:1. Сүнсний дуу хоолойг сонсдог тэд гэгээрч мөн Эцэгт ирдэг билээ, **С ба Г** 84:46–47. Тэд Их Эзэнийг сонсохдоо удаан байв; тиймийн тул, тэрээр тэдний залбирлуудыг сонсохдоо удаан байв, **С ба Г** 101:7–9. Зарлигуудыг сонсдоггүй тэд зэмлэгддэг билээ, **С ба Г** 103:4 (Моисе 4:4).

АНХНЫ ҮЗЭГ ДЭЛ. Бага Иосеф Смит; Сайн Мэдээний Сэргээлтийг мөн үз.

Бурхан Эцэг түүний Хүү Есүс Христ хоёр Бошиглогч Иосеф Смитэд ойн цоорхойд хүрч ирсэн үйл явдал.

1820 оны хавар Бага Иосеф Смит

арван тавтай байв. Тэрээр Нью-Йоркийн дагуул хот Палмирад гэр бүлийнхээ хамт амьдарч байлаа. Тэдний гэрээс баруун тийш их моддын дунд нэг ойн цооорхой байдаг байв. Аль сүм үнэн болохыг мэдэхийн тулд Иосеф Библийг уншиж байхдаа тэрээр уг асуултын хариуг Бурханаас эрэлхийлэх ёстой гэсэн сэтгэгдэл түүнд төржээ. (Иаков 1:5–6) Залбирлынх нь хариуд Эцэг, Хүү хоёр түүн дээр хүрч ирэн, дэлхий дээр байсан сүмүүдийн алинд нь ч элсэх хэрэггүйг түүнд хэлэв, учир нь тэд бүгдээрээ буруу байжээ (ИС—Г 1:15–20). Энэхүү ариун туршлага нь сайн мэдээ хийгээд Христийн үнэн сүмийг сэргээхтэй холбогдсон цуврал үйл явлуудын эхлэлийг тавьсан юм.

АНХНЫ ҮР ЖИМС

Улиралд хураадаг анхны ургац. Хуучин Гэрээний үед анхны ургацыг Их Эзэнд өргөл болгодог байв (Лев. 23:9–20). Сайн мэдээг хүлээн зөвшөөрч итгэлтэй байдалд эцсээ хүртэл тэвчдэг хүмүүс бэлэгдлийн хувьд анхны үр жимс юм, учир нь тэд Бурханд харьяалагддаг билээ.

Хургыг хаашаа ч явсан, түүнийг дагадаг хүмүүс бол Бурханд анхны үр жимсүүд юм, **Илч.** 14:4. Христтэй хамт анх түрүүн дээшлэх тэд бол анхны үр жимсүүд билээ, **С ба Г** 88:98.

АПОКАЛИПС. Иоханы
Илчлэлтийг мөн үз

Шинэ Гэрээний сүүлчийн ном, Илчлэлтийн ном; тэрчлэн аливаа гайхмаар илчлэлт байж болно; “Илчлэгдсэн” буюу “нээгдсэн” гэсэн утгатай грек үгнээс үүсэлтэй.

АПОКРИФ. Библи; Судруудыг
мөн үз

Еврей Библид ороогүй боловч Христийн зарим сүмийн Библид хадгалагдан үлдсэн иудей хүмүүсийн ариун нандин номнууд. Эдгээр номнууд нь ихэнхдээ Хуучин

ба Шинэ Гэрээг холбоход үнэ цэнэтэй бөгөөд тэдгээрийг унших нь ашигтай хэмээн Сүмд үздэг.

Апокрифын олон зүйл зөв орчуулагдсан боловч зөв бус засваруудтай, **С ба Г** 91:1–3. Сүнсээр гэгээрэгдсэн тэдэнд Апокриф ашиг тустай байж чадна, **С ба Г** 91:4–6.

АРАВНЫ НЭГ, АРАВНЫ НЭГИЙН ӨРГӨЛ. Мөнгө; Өргөлийг мөн үз

Сүмээр дамжуулан Их Эзэнд хүний өгөх жилийн орлогын аравны нэг. Аравны нэгийн хуримтлал нь сүмүүд болон ариун сүмүүдийг барих, номлолын ажлыг дэмжих болон дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулахад хэрэглэгддэг.

Абрахам эзэмшдэг бүхнийхээ аравны нэгийг Мелкизедект өгдөг байв, **Эхл.** 14:18–20 (Евр. 7:1–2, 9; Алма 13:15). Бүх аравны нэг нь Их Эзэнийх; энэ нь Их Эзэнд ариун юм, **Лев.** 27:30–34. Чи үнэхээр олсон бүхнээсээ аравны нэгийг өргө, **Дэд хууль** 14:22, 28. Тэд бүх зүйлийнхээ аравны нэгийг асар их хэмжээгээр хангав, **Шаст.** дэд 31:5. Хүн Бурханыг луйвардах уу? Бид таныг яаж луйвардсан юм бэ? Аравны нэгээр ба өргөлөөр, **Малах.** 3:8–11 (3 Ниф. 24:8–11). Аравны нэгээ төлөх тэрээр түүний ирэлтэд шатаагдах нь үгүй, **С ба Г** 64:23 (С ба Г 85:3). Их Эзэний өргөө түүний хүмүүсийн аравны нэгээр баригдах болно, **С ба Г** 97:11–12. Их Эзэн аравны нэгийн хуулийг илчлэв, **С ба Г** 119. Аравны нэг нь зөвлөлөөр эмхлэгдэх ёстой, **С ба Г** 120.

АРВАН ЗАРЛИГ. Бурханы зарлигууд; Мосег *мөн үз*

Ёс суртахууны зан төлвийг зохицуулахын тулд бошиглогч Мосегоор дамжуулан Бурханы өгсөн арван хууль.

Эдгээрийн еврей нэр нь “Арван Үг” юм. Эдгээр нь мөн Гэрээ (Дэд хууль 9:9) буюу Гэрчлэл (Ег. 25:21; 32:15) хэмээн нэрлэгддэг.

Бурхан арван зарлигийг Мосед мөн түүгээр дамжуулан Израилд өгсөн нь Египетээс Гарсан нь 19:9–20:23; 32:15–19; 34:1-д бичигджээ. Зарлигууд нь Авдранд байрлуулсан хоёр хавтгай чулуун дээр сийлбэрлэгджээ. Түүнээс хойш авдар нь Гэрээний авдар хэмээн нэрлэгдсэн байна (Тоол. 10:33). Дэд Хуулийн 6:4–5 болон Леви 19:18-аас Их Эзэн иш татан, Арван Зарлигийг “хоёр агуу зарлиг” (Мат. 22:37–39) болгон нэгтгэж хураангуйлжээ.

Арван Зарлиг хожмын үеийн илчлэлтүүдэд давтагдсан байдаг (Моз. 12:32–37; 13:12–24; С ба Г 42:18–28; 59:5–13; ИСО, Ег. 34:1–2).

АРВАН ОВОГ. Израилыг үз

АРВАНХОЁРЫН ЗӨВЛӨЛ.

Төлөөлөгчдийг үз

АРВАНХОЁРЫН ЧУУЛГА.

Төлөөлөгчдийг үз

АРИМАТАЕАГИЙН ИОСЕФ

Ариматаеагийн Иосеф бол Санхедрины гишүүн, Есүсийн шавь, баян, мөн итгэлтэй, бидний Их Эзэнийг зэмлэхэд оролцдоггүй байсан израил хүн байв. Цовдлолтын дараа Иосеф Аврагчийн цогцсыг цэвэрхэн маалинга даавуунд ороож, өөрийнхөө агуйн булшинд тавьжээ (Мат. 27:57–60; Марк 15:43–46; Лук 23:50–53; Иохан 19:38–42).

АРИУН, АРИУН НАНДИН.

Ариун байдал; Ариусгал;

Цэвэр, Цэвэр байдлыг *мөн үз*

Эрхэм нандин, бурханлиг шинжтэй буюу сүнс болон ёс суртахууны хувьд цэвэр ариун. Ариуны эсрэг тал нь зуурдын буюу бузар байдал байдаг.

Та нар надад санваартнуудын хаант улс, ариун үндэстэн болно, **Ег.** 19:5–6 (1 Петр 2:9). Их Эзэн Израилд зарлигласан нь: Би ариун учир та нар ариун байцгаа, **Лев.** 11:44–45. Цэвэр гартай, ариун зүрх сэтгэлтэй тэд

түүний ариун газар дээр зогсох болно, **Дуул.** 24:3–4. Миний ард түмэнд бузар ба цэврийн хоорондох ялгааг заагтун, **Езек.** 44:23. Бурхан биднийг ариун дуудлагаар дуудсан юм, **2 Тим.** 1:8–9. Судруудыг чи бага наснаасаа мэдэх болсон, **2 Тим.** 3:15. Бурханы ариун хүмүүс Ариун Сүнсээр хөдөлгөгдсөнийхөө дагуу ярьдаг байв, **2 Петр** 1:21. Бурханд байдаг тэрхүү үнэн болон ариун байдлын дагуу бүх хүмүүн шүүгдэх болно, **2 Ниф.** 2:10. Эгэл хүн Христийн цагаатгалаар дамжин Гэгээнтэн болдог, **Моз.** 3:19. Бурханы ариун жаягийн дагуу алх, **Алма** 7:22 (Алма 13:11–12). Гурван шавь мах бодидоо ариусгагдаж, ариун болгогдсон байлаа, **3 Ниф.** 28:1–9, 36–39. Ариун нандин зүйлүүдэд бүү хөнгөн хуумгай ханд, **С ба Г** 6:12. Надаас чамд өгөгдөхөөс бусдаар ариун нандин тэрхүү зүйлийг чи бичиж чадах нь үгүй, **С ба Г** 9:9. Бүхий л ариун байдалд үйлдэхийн тулд та нар өөрсдөдөө үүрэг хүлээх ёстой, **С ба Г** 43:9. Миний шавь нар ариун газруудад зогсох болно, **С ба Г** 45:32. Дээрээс ирдэг тэрхүү зүйл ариун нандин билээ, **С ба Г** 63:64. Бяцхан хүүхдүүд ариун болой, **С ба Г** 74:7. Тэр хэсэг газрыг ариулан адисла, мөн энэ нь ариун болгогдох болно, **С ба Г** 124:44. Их Эзэн өөрийн сонгосон хүмүүсийг ариун хотод цуглуулах болно, **Мосе** 7:62.

АРИУНААС АРИУН. Асар; Ариун Сүм, Их Эзэний өргөөг *мөн үз*

Мосегийн асар дахь мөн түүнчлэн хожим нь ариун сүм дэх хамгийн ариун нандин өргөө. Ариунаас Ариун нь түүнчлэн хамгийн ариун газар хэмээн нэрлэгддэг (Ег. 26:33–34).

АРИУН БАЙДАЛ. Ариун; Ариусгал; Цэвэр; Цэвэр байдлыг *мөн үз*

Сүнсний хийгээд ёс суртахууны төгс байдал. Ариун байдал нь хүний

зүрх сэтгэлийн болон бодол санааны цэвэр байдлыг багтаадаг.

Гишүүд Их Эзэний өмнө цэвэр ариун байдалд алхаснаар Сүмийн хувьд зохистой гэдгийг харуулах ёстой, **С ба Г** 20:69. Их Эзэний өргөө бол цэвэр ариун байдлын газар мөн, **С ба Г** 109:13. Ариун Хүн бол Бурханы нэр юм, **Мосе** 6:57 (Мосе 7:35).

АРИУН БУС. Бурханлиг бусыг *үз*

АРИУН ЁСЛОЛ. Амьд ус; Амьдралын талх; Баптисм, Баптисм хүртээх; Есүс Христ; Загалмай; Золиослол; Сүүлчийн зоог; Цагаатгал, Цагаатгахыг *мөн үз*

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хувьд *ариун ёслол* гэдэг нь Христийн цагаатгагч золиослолыг дурсан санахын тулд талх, усыг хүртдэг ёслол юм. Үйрүүлсэн талх нь түүний зовсон биеийг төлөөлдөг; ус нь бидний гэм нүглийг цагаатгахаар урсгасан түүнийг цусыг төлөөлдөг (1 Кор. 11:23–25; С ба Г 27:2). Сүмийн зохистой гишүүд ариун ёслолоос хүртэхдээ, Христийн нэрийг өөрсөд дээрээ хүлээн авч, түүнийг үргэлж дурсан санаж, мөн зарлигуудыг нь сахина хэмээн амладаг. Энэ ёслолоор дамжуулан Сүмийн гишүүд баптисмын гэрээгээ шинэчилдэг.

Сүүлчийн зоог дээр Арванхоёр Төлөөлөгчтэй хамт хооллож байхдаа Есүс ариун ёслолын ёслолыг тайлбарлажээ (Мат. 26:17–28; Лук 22:1–20).

Есүс талх авч үүнийг адислав; мөн тэр аягатайг авч мөн талархал өргөв, **Мат.** 26:26–28 (Марк 14:22–24; Лук 22:19–20). Хэн миний биеийг идэж, мөн миний цусыг ууна, түүнд мөнх амьдрал байх болно, **Иохан** 6:54. Зохисгүйгээр идэж мөн уусан тэрээр өөрийн бодгальд ялыг идэж мөн уудаг, **1 Кор.** 11:29 (3 Ниф. 18:29). Есүс өөрийнхөө арванхоёр нифай шавьд ариун ёслолын тухай заав,

3 Ниф. 18:1–11. Ариун ёслолоос зохистой бус хүмүүс хүртэхийг хоригло хэмээн Есүс эдгээр шавь нартаа заажээ, **3 Ниф.** 18:28–29 (Морм. 9:29). Ариун ёслолын залбирал өгөгдөв, **Моро.** 4–5 (С ба Г 20:75–79). Ариун ёслол нь санваартан буюу ахлагчаар гүйцэтгэгддэг байх ёстой, **С ба Г** 20:46, 76. Багш буюу дикон нь ариун ёслолыг адислах эрх мэдэлгүй болой, **С ба Г** 20:58. Дарснаас бусад шингэн ариун ёслолд хэрэглэгдэж болно, **С ба Г** 27:1–4.

АРИУН ЖУРАМ. Ариун явдал;

Зарчимч байдал; Хүчийг мөн үз

Зарчимч байдал болон ёс суртахууны онцгой байдал, хүч хийгээд хүч чадал (Лук 8:46), эсвэл бэлгийн харилцааны цэвэр ариун байдал (Моро. 9:9).

Чи бол ариун журамт бүсгүй болой, **Рут** 3:11. Цэвэр гар хийгээд ариун зүрх сэтгэлтэй тэрээр Их Эзэний ариун газарт зогсох болно, **Дуул.** 24:3–4. Сайн эхнэр нь нөхөртөө титэн юм, **Сур.** үгс 12:4. Арван хуруу тэгш эхнэр эрдэнэсээс ч үнэтэй, **Сур.** үгс 31:10–31. Итгэл дээрээ сайн давуу байдлыг нэм, **2 Петр** 1:5 (С ба Г 4:6). Бурханы үгийн нөлөөлөх хүчийг сорив, **Алма** 31:5. Ариун журам нь чиний бодлуудыг зогсолтгүйгээр тэтгэг, **С ба Г** 121:45. Ариун журамтай байхад бид итгэдэг, **ИТ** 1:13 (Филип. 4:8).

АРИУН ОЙН ЦООРХОЙ. Анхны

Үзэгдлийг үз

АРИУН СҮМ, ИХ ЭЗЭНИЙ

ӨРГӨӨ. Ариунаас Ариун; Асар;

Ёслолууд; Хишгийг мөн үз

Үгчлэн хэлбэл, Их Эзэний өргөө. Зохистой Гэгээнтнүүд сайн мэдээний эрхэм ариун ёс жаягууд хийгээд ёслолуудыг өөрсдийнхөө төлөө бас нас барагсдын төлөө гүйцэтгэдэг ариун барилгууд—ариун сүмүүд барихыг Их Эзэн өөрийн хүмүүст байнга зарлигладаг. Их Эзэн өөрийн-

хөө ариун сүмд зочилдог бөгөөд тэдгээр нь шүтээний бүх газруудаас хамгийн ариун нь юм.

Мосе болон Израилын хүүхдүүдийн босгосон асар нь зөөврийн ариун сүм байв. Израилчууд үүнийг Египетээс гарах үедээ хэрэглэсэн ажээ.

Библид дурдагддаг бүхний мэдэх ариун сүм нь Иерусалимд барьсан Соломоны ариун сүм юм (Шаст. дэд 2–5). Уг ариун сүм мээ 600 онд вавилончуудаар устгагдаж, Зерубабел ойролцоогоор зуун жилийн дараа үүнийг дахин сэргээжээ (Езра 1–6). Энэ ариун сүмийн хэсэг нь мээ 37 онд шатаагдсан бөгөөд Их Херод хожим нь дахин сэргээжээ. Ромчууд ариун сүмийг мээ 70 онд устгасан юм.

Мормоны Номонд Бурханы зөв шударга дагалдагчид ариун сүмүүд барьж шүтэхээр удирдагдсан байв (2 Ниф. 5:16; Моз. 1:18; 3 Ниф. 11:1). Ариун сүмүүдийг барьж мөн зохистойгоор ашиглах нь аль ч эрин үеийн, ялангуяа манай үеийн сэргээгдсэн Сүм, үнэн Сүмийн тэмдэг юм. Көртландын Ариун Сүм бол энэ эрин үед баригдаж мөн Их Эзэнд онцгойлон адислагдсан анхны ариун сүм мөн. Тэр цагаас хойш дэлхийн олон нутагт газар сайгүй ариун сүмүүд онцгойлон адислагдсаар байна.

Ариун газарт хэн зогсох ёстой вэ? **Дуул.** 24:3–5. Бүгдээрээ Иаковын Бурханы өргөө уруу явцгаая, **Иса.** 2:2–3 (Мика 4:1–2; 2 Ниф. 12:2–3). Их Эзэн өөрийнхөө ариун сүмд гэнэт ирэх болно, **Малах.** 3:1 (3 Ниф. 24:1; С ба Г 36:8; 42:36). Есүс ариун сүмийг цэвэршүүлсэн билээ, **Мат.** 21:12–16 (Марк 11:15–18; Лук 19:45–48). Миссурид ариун сүм барихаар гэгээнтнүүд зарлигдуулав, **С ба Г** 57:3 (С ба Г 84:3–5). Бурханы өргөө босго, **С ба Г** 88:119 (С ба Г 109:8). Ариун сүм барихдаа бүтэлгүйтсэн тул Их Эзэн Гэгээнтнүүдийг зэмлэв, **С ба Г** 95:1–12. Ариун бус сүмд би ирэхгүй, **С ба Г** 97:15–17. Би энэ

өргөөг хүлээн зөвшөөрлөө, мөн миний нэр энд байх болно, **С ба Г** 110:7–8. Их Эзэний хүмүүс үргэлж түүний нэрэнд өргөө барихаар зарлигдуулдаг, **С ба Г** 124:39. Ариун сүмүүдэд хийгдэх ёстой агуу ажил нь хүүхдүүдийг эцэг эхтэй нь лацдан холбохыг багтаадаг, **С ба Г** 138:47–48. Ариун сүмүүдийг барих нь хожмын үеийн агуу ажилд багтдаг, **С ба Г** 138:53–54.

АРИУН СҮМИЙН ГЭРЛЭЛТ.

Гэрлэлт, Гэрлэхийг үз

АРИУН СҮНС. Амлалтын Ариун Сүнс; Баптисм, Ариун Сүнсний бэлэг; Баптисм хүртээх; Бурхан, Бурхан Тэргүүтэн; Бурханлиг нөлөө; Бурханлигаар нөлөөлөгдөх; Илчлэлт; Тагтаа; Тагтаан тэмдэг; Тайтгаруулагч; Уучлагдашгүй нүглийг мөн үз

Бурхан Тэргүүтний гурав дахь гишүүн (1 Иохан 5:7; **С ба Г** 20:28). Тэр бол мах болон ясан биегүй Сүнсэн хүн (**С ба Г** 130:22). Ариун Сүнсийг Сүнс, эсвэл Бурханы Сүнс гэсэн нь олонтаа тохиолддог.

Ариун Сүнс авралын төлөвлөгөөнд хэд хэдэн чухал үүрэг гүйцэтгэдэг. (1) Тэрээр Эцэг болон Хүүгийн тухай гэрчилдэг (1 Кор. 12:3; 3 Ниф. 28:11; Ифер 12:41). (2) Тэрээр бүх зүйлийн тухай үнэнийг илчилдэг (Иохан 14:26; 16:13; Моро. 10:5; **С ба Г** 39:6). (3) Наманчилж мөн баптисм хүртсэн хүмүүсийг тэрээр ариусгадаг (Иохан 3:5; 3 Ниф. 27:20; Мосе 6:64–68). (4) Тэр бол Амлалтын Ариун Сүнс мөн (**С ба Г** 76:50–53; 132:7; 18–19, 26).

Баптисм хүртэхээс өмнө Ариун Сүнсний хүч хүнд ирж сайн мэдээ үнэн гэдгийг гэрчлэх болно. Гэвч хүн зохистой байгаа үед Ариун Сүнсний байнгын нөхөрлөлтэй байх эрх нь Есүс Христийн үнэн сүм дэх эрх мэдэл бүхий баптисмын дараа зөвхөн Мелкизедек санваарыг атгагчаар гар тавиулан хүлээн авч болдог бэлэг юм.

Ариун Сүнсийг доромжлохоос бусад бүх нүглүүдийг уучилж болно хэмээн Есүс заадаг байлаа (Мат. 12:31–32; Марк 3:28–29; Лук 12:10; Евр. 6:4–8; **С ба Г** 76:34–35).

Сүнс хүмүүнийг Бурханы тогтоолуудаар явахад хүргэдэг, **Езек.** 36:27. Эцэг, Хүү мөн Ариун Сүнсний нэрээр баптисм хүртэхээр Төлөөлөгчид итгэмжлэл хүлэв, **Мат.** 28:19. Ариун Сүнс та нарт бүх зүйлийг заах болно, **Иохан** 14:26. Ариун хүмүүс Ариун Сүнсээр хөдөлгөгдсөнөөрөө ярьдаг байв, **2 Петр** 1:21. Нифай Сүнсээр удирдагдаж байв, **1 Ниф.** 4:6. Бурханы нууцууд тэдэнд Ариун Сүнсний хүчээр нээгдэх болно, **1 Ниф.** 10:17–19. Та нарын хийх ёстой бүх зүйлийг Ариун Сүнс үзүүлдэг, **2 Ниф.** 32:5. Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн үнэнийг мэдэж болно, **Моро.** 10:5. Ариун Сүнс чамд оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь ярих болно, **С ба Г** 8:2. Сүнс сайныг үйлдэхэд хөтөлдөг, **С ба Г** 11:12. Ариун Сүнс бүх зүйлийг мэддэг, **С ба Г** 35:19. Ариун Сүнс хаант улсын амар амгалангийн зүйлүүдийг заадаг, **С ба Г** 36:2 (**С ба Г** 39:6). Хэрэв та нар Сүнсийг үл хүлээн авбаас, та нар зааж чадахгүй, **С ба Г** 42:14. Ариун Сүнс Эцэгийн тухай, мөн Хүүгийн тухай гэрчилдэг, **С ба Г** 42:17 (1 Кор. 12:3; 3 Ниф. 11:32, 35–36). Есүс Христ бол Бурханы Хүү гэдгийг мэдэх нь Ариун Сүнсээр заримд нь өгөгддөг, **С ба Г** 46:13. Ариун Сүнсээр урагш хөдөлгөгдөх тэд юуг ч ярилаа гэсэн судар байх ёстой, **С ба Г** 68:4. Та нарын хэлэх юу ч байлаа, бүх зүйлүүдэд Ариун Сүнс тэрчлэн урагш юүлэгдэх болно, **С ба Г** 100:8. Ариун Сүнс чиний байнгын хамтрагч байх болно, **С ба Г** 121:45–46.

АРИУН СҮНСНИЙ БЭЛЭГ.

Ариун Сүнс; Бурхан, Бурхан Тэргүүтэн; Бэлэг; Сүнсний бэлгүүдийг мөн үз

Ариун Сүнсний байнгын нөлөөлөлтэй байх нь баптисм хүртсэн, Сү-

мийн зохистой гишүүн болгоны эрх юм. Есүс Христийн үнэн Сүмд хүн баптисм хүртсэний дараа, тэрээр зохих эрх мэдэл бүхий хэн нэгнээс гар тавилтаар Ариун Сүнсний бэлгийг хүлээн авдаг (Үйлс 8:12–25; Моро. 2:1–3; С ба Г 39:23). Ариун Сүнсний бэлэг хүлээн авахыг галаар баптисм хүртээх гэж хэлэх нь олон-таа байдаг (Мат. 3:11; С ба Г 19:31).

Хүмүүс наманчилж, баптисм хүртэж, мөн Ариун Сүнсний бэлэг хүлээн авахаар зарлигдуулсан байдаг, **Үйлс** 2:38. Петр, Иохан хоёр гар тавилтаар Ариун Сүнсний бэлэг хүртээж байв, **Үйлс** 8:14–22. Ариун Сүнс гар тавилтаар өгөгддөг, **Үйлс** 19:2–6. Нүглүүдийн ангижрал нь галаар хийгээд Ариун Сүнсээр ирдэг, **2 Ниф.** 31:17. Ариун Сүнсний бэлгийн төлөөх гар тавилтад бид итгэдэг, **ИТ** 1:4.

АРИУН ХҮН. Бурхан, Бурхан
Тэргүүтэн; Тэнгэр дэх Эцэг;
Хүний Хүүг *мөн үз*

Бурхан Эцэгийн өөр нэг нэр
(Моисе 6:57).

АРИУН ЯВДАЛ. Ариун журам;
Завхайрал; Садар самуун;
Тачаангуй, Тачаадалтыг *мөн үз*

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн
бэлгийн харилцааны цэвэр ариун
байдал.

Иосеф Погифарын эхнэрийн сээ-тэгнэлийг эсэргүүцэв, **Эхл.** 39:7–21 (С ба Г 42:24; 59:6). Садар самууныг бүү үйлд, **Ег.** 20:14. Сайн эхнэр нөхөртөө титэм юм, **Сур.** үг 12:4 (Сур. үгс 31:10). Бие чинь Ариун Сүнсний ариун сүм гэдгийг та нар мэддэггүй юм уу? **1 Кор.** 6:18–19. Та нар цэвэр байдлаараа үлгэр дууриал бай, **1 Тим.** 4:12. Цэвэр бус нэгээхэн ч зүйл Бурхантай хамт оршиж эс чадна, **1 Ниф.** 10:21. Учир нь би, Их Эзэн Бурхан эмэгтэйчүүдийн ариун явдалд баясдаг, **Иаков** 2:28. Хурьцлын нүгэл нь жигшүүрт хэрэг юм, **Алма** 39:1–13. Ариун явдал, ариун

журам нь бүхнээс хамгийн эрхэм үнэтэй нь юм, **Моро.** 9:9. Ариун явдалтай байхад бид итгэдэг, **ИТ** 1:13.

АРИУСГАЛ. Есүс Христ; Зөвтгөл,
Зөвтгөх; Цагаатгал,
Цагаатгахыг *мөн үз*

Есүс Христийн цагаатгалаар нүглээс ангид, ариун, цэвэр ариун болох үйл явц (Моисе 6:59–60).

Бурхан та нарыг Сүнсний ариусгалаар дамжуулан авралын төлөө сонгосон, **2 Тес.** 2:13. Бид Есүс Христийн биеэ өргөсөн өргөлөөр дамжуулан ариусгагдсан билээ, **Евр.** 10:10. Есүс өөрийнхөө цусаар хүмүүсийг ариусгахын тулд зовсон юм, **Евр.** 13:12. Дээд санваартнууд ариусгадаж мөн тэдний өмсгөлүүд Хурганы цусаар угаагдан цагаан болгогдсон байв, **Алма** 13:10–12. Ариусгал нь Бурханд зүрх сэтгэлээ зориулсан хүмүүст ирдэг, **Хил.** 3:33–35. Ариун Сүнсний хүлээн авалтаар ариусгадаж болохын тулд наманчил, **3 Ниф.** 27:20. Есүс Христийн ач ивээлээр дамжсан ариусгал нь шударга хийгээд үнэн болтой, **С ба Г** 20:31. Есүс дэлхийг ариусгахаар ирсэн юм, **С ба Г** 76:41. Оюун чинь Бурханд чиглэсэн байхын тулд өөрийгөө ариусга, **С ба Г** 88:68.

АРМАГЕДДОН. Гог; Есүс
Христийн Хоёр дахь Ирэлт;
Магогийг *мөн үз*

Армагеддон гэдэг нэр нь “Мегиддо уул” гэсэн утгатай *Хаар Мегиддон* гэсэн еврей үгнээс гаралтай. Мегиддогийн хөндий бол Иерусалимаас хойш тавин мильд (наян километр) Езраелоны талын баруун хэсэг ба Хуучин Гэрээний үеийн хэд хэдэн шийдвэрлэх тулалдааны талбар юм. Их Эзэний хоёр дахь ирэлтийн ойролцоо болох агуу хийгээд сүүлчийн мөргөлдөөн мөнхүү энэ газарт болох учраас үүнийг Армагеддоны тулаан хэмээн нэрлэх болно (Езек. 39:11; Зех. 12–14, ялангуяа 12:11; Илч. 16:14–21).

АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДАА.Мэргэн Ухааны Үгийг *мөн үз***АСА**

Хуучин Гэрээнд Иудейн гурав дахь хаан. Өөрийн бүх л өдрүүдийн турш зүрх сэтгэл нь Их Эзэнд төгс зориулагдаж байсан хэмээн судрууд тэмдэглэжээ (Хаад. дээд 15:14). Хаанчлалынхаа үед тэрээр хүчирхэг арми бий болгож, Етиопийн дарлалыг нураан, хуурамч шүтээнүүдийг зайлуулж, Иеховаг эрж олох гэрээг хүмүүстэй хийжээ (Хаад. дээд 15-16; Шаст. дэд 14-16). Хэдий тийм ч тэрээр хөлдөө өвчтэй болсон үедээ Их Эзэний тусламжийг хүсээгүйн улмаас нас эцэслэжээ (Хаад. дээд 15:23-24; Шаст. дэд 16:12-13).

АСАР. Ариун сүм; АриунаасАриун; Гэрээний авдар; Их Эзэний өргөөг *мөн үз*

Египетээс гарах үе дэх израилчуудын шүтээний төв, Их Эзэний өргөө. Асар нь үнэндээ авсаархан ариун сүм бөгөөд зөөж мөн буцаан босгож болдог байв. Соломоны ариун сүмийг босгох хүртэл Израилын хүүхдүүд асар ашигладаг байв (С ба Г 124:38).

Асрын загварыг Бурхан Мосед илчилсэн (Ег. 26-27) бөгөөд Израилын хүүхдүүд тэр загварын дагуу үүнийг барьжээ (Ег. 35-40). Асар дуусахад майхныг үүл нөмөрч, Их Эзэний алдар суу асрыг дүүргэв (Ег. 40:33-34). Үүл нь Бурханы оршихуйн тэмдэг байв. Энэ нь шөнө галын байдалтай байлаа. Үүл майхан дээр тогтоход Израилын хүүхдүүд буудаллав. Үүл нүүхэд тэд үүнтэй хамт нүүцгээдэг байжээ (Ег. 40:36-38; Тоол. 9:17-18). Израилын хүүхдүүд цөлд хэрэн явахдаа хийгээд Канааны нутгийг эзлэхдээ асраа авч явжээ. Эзэлснийхээ дараа асрыг Их Эзэний сонгосон газар Шилод байрлуулжээ (Иош. 18:1). Израилын хүүхдүүд Соломоны ариун сүмийг барьсны дараа асар түүхээс бүрмөсөн алга болжээ.

Их Эзэн болон Исаиа асрыг Их

Эзэний хоёр дахь ирэлтийн үе дэх Сион болон Иерусалим хотуудын бэлэгдэл болгон ашиглажээ (Иса. 33:20; Мосе 7:62).

АССИРИ

Хуучин Гэрээний үеийн ихэнх үед Сири болон Палестины хуучин мужуудыг захирч байсан, Вавилоны өрсөлдөгч, эртний хаант улс. Хэдийгээр мээ 12-р зууны дунд үеэс мээ 7-р зууныг хүртэл Ассиричууд их хүчтэй байсан боловч тэд улс төрийн тогтвортой бүтцийг хэзээ ч бүрдүүлж чадаагүй байна. Тэд аллагаар захирч дайснуудаа галаар болон сэлмээр нухчин дарж эзэнт гүрнийхээ бусад хэсгүүд уруу хүн амын ихэнх хэсгийг цөлж суурьшуулдаг байжээ. Тэдэнд захирагдсан хараат улс орнууд цаг ямагт дайсан нь байсан бөгөөд эзэнт гүрний бүх үеийн түүхэнд бослого байнга гарч байжээ. (Хаад. дэд 18-19; Шаст. дэд 32; Иса. 7:17-20; 10; 19; 37).

АСУУХ, ГУЙХ. Залбирлыг *мөн үз*

Бурханаас онцгой хүсэлт хүсэх, асуух буюу гуйх айлтгал.

Асуу, тэгвэл энэ нь танд өгөгдөх болно, **Мат.** 7:7. Хэрэв хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал Бурханаас асууг, **Иаков** 1:5 (ИС — Т 1:7-20). Итгэлээр надаас асуу, **1 Ниф.** 15:11. Хэрэв та нар эдгээр үгсийг ойлгож үл чадах аваас энэ нь та нар асуугаагүйн улмаас болой, **2 Ниф.** 32:4. Чин сэтгэлээсээ асуу, **Моз.** 4:10. Итгэлтэйгээр та нарын асуух, зөв болох юуг ч Бурхан та нарт соёрхдог, **Моз.** 4:21. Эдгээр зүйлүүд үнэн эсэхийг Бурханаас асуу, **Моро.** 10:4. Тэд гэрлээс илүү харанхуйд хайртай учраас, тэд надаас асуух нь үгүй, **С ба Г** 10:21. Бүх зүйлийг Бурханаас асуух нь чамд зарлиглагдсан бөлгөө, **С ба Г** 46:7.

АТААРХАЛ. Атаа жөтөө; Атаа жөтөөч; Шуналыг *мөн үз*.

Судруудынхаар, өөр хүнд байдаг ямар нэг зүйлийг эгээрэн хүсэх нь буруу юм.

Өвөг дээдэс нь Иосефт атаархах болж, түүнийг Египетэд худалдав, **Үйлс** 7:9. Энэрэл атаархдаггүй, **1 Кор.** 13:4 (Моро. 7:45). Атаархал нь бардамналаас ирдэг, **1 Тим.** 6:4. Хаана атаархал байна, тэнд эмх замбараагүй байдал хийгээд аливаа хилэнцэг үйл байдаг, **Иаков** 3:16. Хүмүүн атаархах ёсгүй хэмээн Их Эзэн тэдэнд зарлиглажээ, **2 Ниф.** 26:32. Нифайн хүмүүсийн дунд атаархал байсангүй, **4 Ниф.** 1:15–18. Хүмүүний атаархал хийгээд хилэгнэл амьдралын минь бүх өдрүүдэд миний нийтлэг хувь тавилан байлаа, **С ба Г** 127:2.

АТАА ЖӨТӨӨ, АТААРХУУ.

Атаархлыг *мөн үз*

Атаархуу гэдэг үг судруудад хоёр өөр утгаар хэрэглэгдсэн байдаг: (1) хэн нэгний буюу ямар нэг юмны талаар хор шартай, хартай буюу эсвэл эмзэг, гүнзгий мэдрэмжтэй байх, (2) өөр хүн өөрөөс нь давуутай болох вий хэмээн атаархах.

Хор шартай буюу хартай байх мэдрэмж: Эзэн би бол хартай Бурхан, **Ег.** 20:5 (Дэд хууль 5:9; 6:15; Моз. 11:22). Би өөрийн ариун нэрийн тул хартай байх болно, **Езек.** 39:25. Би Иерусалим болон Сионы төлөө хартай байдаг билээ, **Зехар.** 1:14.

Атаархуу байх буюу хардах: Хардалт нь эр хүний хилэнг бадраадаг, **Сур.** үгс 6:32–35. Акиш хүүдээ атаархаж эхлэв, **Ифер** 9:7. Өөрсдийгөө атаа жөтөө хийгээд айдсаас ангид байлга, **С ба Г** 67:10.

АХАБ. Иезебелийг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Умард Израилын хамгийн ёс бус хийгээд хүчирхэг хаадын нэг. Тэрээр Сидоны гүнж Иезебелтэй гэрлэж, түүний нөлөөгөөр Баал болон Аштрохыг шүтэн бишрэх явдал Израилд үндэслэгдэж (Хаад. дээд 16:29–33; Хаад. Дэд 3:2), тийнхүү бошиглогчид хийгээд Иеховаг бишрэн шүтэхийг зайлуулах оролдлого хийгдэх болжээ (Хаад. дээд 18:13)

Самарид Израилын дээр хорин хоёр жил хаанчилжээ, **Хаад. дээд** 16:29 (Хаад. дээд. 16–22). Өөрөөсөө өмнө байсан бусдаас илүүгээр Их Эзэний мэлмийн өмнө хилэнцийг үйлджээ, **Хаад. дээд** 16:30. Тулалдаанд амь үрэгджээ, **Хаад. дээд** 22:29–40.

АХАН ДҮҮС, АХ. Хүмүүс,

Эрэгтэй хүн, Эгчийг *мөн үз*

Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн хувьд бүх эрэгтэй, эмэгтэй хүмүүс сүнслэг ах эгч дүүс билээ. Сүмд эрэгтэй гишүүд болон Сүмийн найз нар ихэнхдээ ах нар хэмээн нэрлэгддэг.

Чи хөрвүүлэгдээд ах нараа хүчирхэгжүүл, **Лук** 22:32. Өөрийнхөө ахыг хайрладаггүй тэр нь үхэлд ойрхон байдаг, **1 Иохан** 3:10–17. Ах нараа өөрийнхөө адил бод, **Иаков** 2:17. Хүн бүхэн ахыгаа өөрийн адил хайрлан хүндэтгэ, **С ба Г** 38:24–25. Өөрийн бүх яриандаа ах нараа хүчирхэгжүүл, **С ба Г** 108:7.

АХЛАГЧ. Мелкизедек санваар;

Санваарыг *мөн үз*

Ахлагч гэдэг нэр томьёо нь Библид хэдэн өөр байдлаар хэрэглэгддэг. Хуучин Гэрээнд энэ нь ерөнхийдөө засаглалын хэрэгт итгэл хүлээлгэсэн ихэнхдээ овгийн хамгийн настай хүнийг хэлдэг (Эхл. 50:7; Иош. 20:4; Рут 4:2; Мат. 15:2). Тэдний нас болон туршлага зөвлөгөөг нь үнэ цэнэтэй болгодог. Тэдний албан тушаал санваарын дуудлага байх шаардлагагүй байв.

Хуучин Гэрээний үед ахлагчид тэрчлэн Мелкизедек санваарт томилогддог байв (Ег. 24:9–11). Шинэ Гэрээнд, ахлагчид нь Сүм дэх санваартны албан тушаал болж дурдагддаг байв (Иаков 5:14–15). Нифайчуудын дунд мөн санваарт томилогдсон ахлагчид байжээ (Алма 4:7; 16; Моро. 3:1). Энэ эрин үед Иосеф Смит, Оливер Каудери нар томилогдсон анхны ахлагчид байв (С ба Г 20:2–3).

Эдүгээ ахлагч нь бүх Мелкизедек

санваартнуудад өгсөн нэр юм. Жишээ нь, эрэгтэй номлогчид ахлагчид хэмээн нэрлэгддэг. Мөн Төлөөлөгч бол ахлагч, мөн Арванхоёрын Чуулга болон Далын Чуулгуудыг энэ нэрээр дуудах нь зохимжтой (С ба Г 20:38; 1 Петр 5:1). Сүмд томилогдсон ахлагчдын үүргүүд өнөөдөр хожмын үеийн илчлэлтүүдэд өгөгдсөн байдаг (С ба Г 20:38–45; 42:44; 46:2; 107:12).

Моше Израилын бүх ахлагчдад бичжээ, **Дэд хууль** 31:9. Барнаб сүмийн ахлагчдад тусламж явуулсан, **Үйлс** 11:30. Бүх сүмүүдэд Ахлагчдыг томилов, **Үйлс** 14:23 (Тит 1:5). Ахлагчдыг өвчтөний төлөө залбируулахаар дууд, **Иаков** 5:14. Ахлагчид гар тавилтаар томилогддог, **Алма** 6:1. Ахлагчид хүүхдүүдийг адислах ёстой, **С ба Г** 20:70. Ахлагчид Ариун Сүнсээр цуглааныг удирдах ёстой, **С ба Г** 46:2. Ахлагчид ажил үүргийнхээ тайланг өгөх ёстой, **С ба Г** 72:5. Ахлагчид сайн мэдээг үндэстнүүдэд номлох ёстой, **С ба Г** 133:8.

АХМАД АЛМА

Ёс бус Хаан Ноагийн өдрүүдэд Сүмийг зохион байгуулсан, Мормоны Номон дахь нифайчуудын бошиглогч.

Нифайн удам, ёсон бус Хаан Ноагийн санваартан байв, **Моз.** 17:1–2. Абинадайг сонсож мөн итгэсний дараа хаанаар зайлуулагджээ. Тэрээр зугтан, нуугдаж мөн Абинадайн үгсийг бичив, **Моз.** 17:3–4. Наманчилж мөн Абинадайн үгсийг заав, **Моз.** 18:1. Мормоны Усанд баптисм хүртэв, **Моз.** 18:12–16. Сүмийг зохион байгуулав, **Моз.** 18:17–29. Хүмүүсийнхээ хамт Зарахемлад хүрч ирэв, **Моз.** 24:25. Сүмийн дээрх эрх мэдлийг өгөв, **Моз.** 26:8. Сүмийг шүүж мөн удирдав, **Моз.** 26:34–39. Хүүдээ дээд санваартны албан тушаал олгов, **Алма** 4:4 (Моз. 29:42, Алма 5:3).

АЧ ИВЭЭЛ. Аврал; Есүс Христ;
Нигүүлсэл, Нигүүлсэнгүй;

Цагаатгал, Цагаатгахыг
мөн үз

Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд итгэлтэй байж наманчлан, мөн зарлигуудыг сахихын тулд дээд зэргийн хүч чармайлт тавьсны үр дүнд энэ амьдралд адислалууд хүлээн авч, мөн мөнх амьдралыг олох боломжийг олгогч Бурханаас ирдэг хүч. Ийм бурханлиг тусламж буюу хүч чадал нь Бурханы нигүүлсэл хийгээд хайраар дамжин өгөгддөг. Адамын уналтын улмаас, тэрчлэн хүмүүний сул дорой байдлын улмаас мөнх бус хүн болгонд бурханлиг ач ивээл шаардлагатай байдаг.

Нигүүлсэл ба үнэн нь Христээр ирсэн билээ, **Иохан** 1:17. Христийн нигүүлслээр дамжин бид аврагдах болно, **Үйлс** 15:11 (Ром 3:23–24; С ба Г 138:14). Бид итгэлээр дамжуулан Түүний нигүүлсэл уруу орох болно, **Ром** 5:2. Итгэлээр дамжуулан нигүүлслээр та нар аврагддаг, **Еф.** 2:8. Бурханы нигүүлсэл авралыг авчирдаг, **Тит** 2:11. Нигүүлслийн хаан ширээнд зоригтойгоор очигцоо, **Евр.** 4:16 Бурхан даруу хүмүүст нигүүлслийг өгдөг, **1 Петр** 5:5. Ариун Мессагийн сайн үйл мөн нигүүлсэл ач ивээлээр биш болбоос, хэн ч Бурханы дэргэд оршиж чадахгүй, **2 Ниф.** 2:8. Зөвхөн Бурханы ач ивээлд мөн үүгээр дамжин хүмүүн аврагдах бөлгөө, **2 Ниф.** 10:24. Бид чадах бүхнээ хийсний дараа нигүүлслээр аврагдана, **2 Ниф.** 25:23. Эдгээр зүйлүүдийг хийх хүч бидэнд байдаг нь нигүүлслээр болой, **Иаков** 4:7. Хүмүүн үйлүүдийнхээ дагуу ач ивээлийн тул ач ивээлд сэргээгдэж болох бөлгөө, **Хил.** 12:24. Номхон дөлгөөн тэдэнд мөн өөрсдийгөө даруусгадаг тэд бүгдэд миний ач ивээл хангалттай, **Ифер.** 12:26–27. Харийнханд ач ивээл хайрлагдсан байхын тулд, тэдэнд энэрэл байхын тулд Моронай залбирав, **Ифер.** 12:36, 41. Бурханы ач ивээлээр та нар Христэд төгс билээ, **Моро.** 10:32–33.

Есүс нигүүлслийн тул, нигүүлслийг хүлээн авчээ, **С ба Г** 93:12–13, 20.

АШЕР. Израил; Исаакийн хүү,
Иаковыг мөн үз

Хуучин Гэрээний Иаков болон Леагийн гарын зарц Зилпагийн хүү бөлгөө (Эхл. 30:12–13).

Ашерын удам: Иаков Ашерыг адислав (Эхл. 49:20), мөн Мосе Ашерын үр удмыг адислав (Дэд хууль 33:1; 24–29). Эдгээр удмынхныг “шалгарсан, баатар эрчүүд” хэмээн нэрлэдэг байв (Шаст. дээд 7:40).

БААЛ. Хиймэл шүтээнийг мөн үз

Ихэвчлэн эрэгтэй наран-бурхан, Фоеникид шүтэгддэг (Хаад. дээд 16:31), гэвч бас өөр өөр нутагт өөр өөр байдлаар: Моабчууд Пеорын Баал хэмээн (Тоол. 25:1–3), Шекемд Баал-берит хэмээн (Шүүгч. 8:33; 9:4), Экронд Баал-зебуб (Хаад. дэд 1:2) хэмээн шүтэгддэг байжээ. Баал гэдэг нь Вавилоны Бел тэрчлэн Грекийн Зевстэй адил юм. *Баал* гэдэг үг эзэн түүний зарц хоёрын хоорондын харилцааг илэрхийлдэг. Баалын ердийн бэлэг тэмдэг нь бух байжээ. Ашторет бол ерөнхийдөө Баалын хамт шүтэгддэг эмэгтэй бурхан байв.

Баал нь зарим үед Баалтай холбоотой өөр нэр буюу үгтэй нийлэн Баалын хүмүүстэй хамаатай буюу эсвэл түүний шүтэгдэж байсан газар мэттэй нэгдэн нийлсэн байдаг. Хожим нь, *Баал* гэдэг нь туйлын хилэнцэг утгатай болсны улмаас *Бошет* гэдэг үг үүнийг дээрх нийлмэл нэрүүдэд орлох болжээ. “*Бошет*” гэдэг нь “ичгүүр” гэсэн утгатай.

БАБЕЛ, ВАВИЛОН. Дэлхий;
Небухаднезарыг мөн үз

Вавилоны нийслэл.

Бабел нь Нимродоор үндэслэгдсэн бөгөөд Месопотами буюу Шинар нутгийн хамгийн эртний хотуудын нэг юм (Эхл. 10:8–10). Бабелын цамхаг барьж байх үед Их Эзэн хүмүүний хэлийг будиулжээ (Эхл. 11:1–9);

Ифер 1:3–5, 33–35). Вавилон нь сүүлд Небухаднезарын нийслэл болжээ. Тэрээр асар том хот барьсан бөгөөд балгас нь одоо ч байдаг. Вавилон асар ёсон бус хот болсон бөгөөд түүнээс хойш дэлхийн ёсон бусыг төлөөлүүлэх болжээ.

Вавилоны дундаас зугт, **Иер** 51:6. Вавилон байгуулагдаж мөн унах болно, **Илч.** 17–18. Вавилон устгагдах болно, **2 Ниф.** 25:15. Вавилон унах болно, **С ба Г** 1:16. Вавилонд үлдэх хэнийг ч би аврахгүй, **С ба Г** 64:24. Та нар Вавилоноос зугт, **С ба Г** 133:5, 7, 14.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН

БАПТИСМ. Аврал—

Хүүхдүүдийн аврал; Баптисм, Баптисм хүртээх—Бага насны хүүхдэд баптисм хүртээх, Хариуцлага, Хариуцлага хүлээх, Хариуцлагын; Хүүхэд, Хүүхдүүдийг мөн үз

Хариуцлагын нас хүрээгүй буюу найман настай хүүхдүүд болон балчир насныханд баптисм хүртээх нь шаардлагатай бус юм. Их Эзэн цага насны хүүхдүүдэд баптисм хүртээхийг зэмлэдэг (Моро. 8:10–21). Хүүхдүүд гэм зэмгүй мөн нүгэлгүй төрдөг. Хүүхдүүдийг хариуцлагын насанд хүртэл тэднийг уруу татах хүч Сатанд байдаггүй (С ба Г 29:46–47), Тиймээс наманчлах буюу баптисм хүртэх шаардлага тэдэнд байдаггүй билээ. Хүүхдүүд найман настайдаа баптисм хүртэх ёстой (С ба Г 68:25–27).

БАГШ, ААРОНЫ САНВААР.

Аароны санваарыг мөн үз

Аароны санваарын албан тушаал.

Сүмийг харж хандах нь багшийн үүрэг болой, **С ба Г** 20:53–60. Багшийн албан тушаал нь бага санваарт шаардлагатай хавсралт юм, **С ба Г** 84:30, 111. Багш нарын чуулгын ерөнхийлөгч нь хорин дөрвөн багшийг тэргүүлдэг, **С ба Г** 107:86.

БАЛААМ

Хуучин Гэрээнд, мөнгөний төлөө Израилыг зүхэхийг хүсч байсан бошиглогч. Израилыг зүхэхгүй байхыг Их Эзэн түүнд зарлиглажээ (Тоол. 22–24).

Тэнгэр элч зам дээр нь зогсож байсан учир Балаамын илжиг урагш явахгүй болов, **Тоол.** 22:22–35.

БАПТИСМ, БАПТИСМ

ХҮРТЭЭХ. Ариун Сүнс; Бага насны хүүхдийн баптисм;
Бурханаас төрөх; Дахин төрөх;
Ёслолуудыг *мөн үз*

Грек хэлний “дүрэх” буюу “умбуулах” гэсэн утгатай үг. Эрх мэдэл бүхий нэгнээр усанд умбуулах баптисм нь сайн мэдээний оршил ёслол бөгөөд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болоход шаардлагатай юм. Энэ нь Есүс Христэд итгэх итгэл болон наманчлалын дараа ирдэг. Ёслолуудыг бүрэн гүйцэтгэхийн тулд үүний дараа Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах шаардлагатай болдог (2 Ниф. 31:13–14). Хүн Селестиед хаант улсад орохын өмнө усаар болон Сүнсээр баптисм хүртэх шаардлагатай. Адам бол анх баптисм хүртсэн хүн байв (Моце 6:64–65). Есүс мөн зөв шударгыг гүйцэлдүүлэхээр мөн замыг бүх хүн төрөлтөнд үзүүлэхээр баптисм хүртжээ (Мат. 3:13–17; 2 Ниф. 31:5–12).

Мөнх бус амьдралдаа сайн мэдээг хүлээн зөвшөөрөх нь дэлхий дээрх бүх хүмүүст боломжгүй учир Их Эзэн баптисмыг нас барсан хүмүүсийн өмнөөс гүйцэтгэх эрхийг огчээ. Тийм учраас, сайн мэдээг сүнсний дэлхийд хүлээн зөвшөөрсөн хүмүүс Бурханы хаант улсад орох шаардлагыг хангаж чадна.

Зайлшгүй шаардлагатай: Аливаа зөвт байдлыг гүйцэлдүүлэхийн тулд энэ удаад үүнийг зөвшөөр, **Мат.** 3:15. Есүс хүрч ирэн Иоханаар баптисм хүртэв, **Марк** 1:9. Фарисайчууд болон хуульчид Бурханы зөвлөгөөг

эсэргүүцэж, баптисм хүртсэнгүй, **Лук** 7:30. Хэн ус болон сүнсээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй, **Иохан** 3:5. Наманчил, та нар бүгдээрээ баптисм хүртсэн бай, **Үйлс** 2:38. Тэрээр бүхий л хүмүүнд түүний нэрээр баптисм хүртэхийг тэдэнд зарлигласан ажгуу, **2 Ниф.** 9:23–24. Хүмүүн аврагдахын тулд Христийг даган баптисм хүртэж, Ариун Сүнсийг хүлээн авч, мөн эцсээ хүртэл тэвчих ёстой, **2 Ниф.** 31. Христийн сургаал бол хүмүүн итгэлтэй байж мөн баптисм хүртэх явдал юм, **3 Ниф.** 11:20–40. Миний нэрээр, нүглүүдийнхээ ангижралын тулд усанд баптисм хүртээгүй тэд хараагдах болно, **С ба Г** 84:74. Наманчлал ба баптисм яагаад шаардлагатайг Бурхан Адамд тайлбарлажээ, **Моце** 6:52–60.

Усанд умбуулах баптисм: Есүс, баптисм хүртээд голын уснаас тэр даруй гарав, **Мат.** 3:16 (Марк 1:10). Тэр газар их устай байсан тул Иохан баптисм хүртээв, **Иохан** 3:23. Филипп тайган хүн хоёр ус уруу оров, **Үйлс** 8:38. Бид баптисмаар түүнтэй оршуулагдсан болой, **Ром** 6:4 (Кол. 2:12). Өөрсдийн Их Эзэн, Аврагчийг даган ус уруу ор, **2 Ниф.** 31:13. Алма, Хелам мөн бусад нь усанд бүрхэгдэв, **Моз.** 18:12–16. Мөн тэгээд чи тэднийг усанд бүрэн дүрэв, **3 Ниф.** 11:25–26. Баптисмын зөв маяг тайлбарлагдав, **С ба Г** 20:72–74. Тэд оршуулгын маягаар баптисм хүртэж, түүний нэрээр усан дотор оршуулагдсан тэд болой, **С ба Г** 76:50–51. Адам усан дор тавигдаж мөн уснаас урагш гаргагдан аваачигдсан байлаа, **Моце** 6:64. Нүглүүдийн ангижралын төлөөх умбуулалт нь баптисм болой, **ИТ** 1:4.

Нүглээс ангижирч баптисм хүртэхүй: Бос, баптисм хүртэж нүглээ угаа, **Үйлс** 22:16. Баптисм ирсний дараа Ариун Сүнсний галаар нүглээсээ ангижир, **2 Ниф.** 31:17. Нүглээсээ угаагдахын тулд наманчлалд баптисм хүрт, **Алма** 7:14. Итгэж мөн баптисм хүртсэн тэд ивээгдсэн,

учир нь тэд нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авна, **3 Ниф.** 12:1–2. Наманчлал хийгээд Аврагчид итгэх итгэл мөн баптисмаар ирэх нүглүүдийн ангижралыг тунхагла, **С ба Г** 19:31. Бид нүглээс ангижирч баптисм хүртэхэд итгэдэг, **ИТ** 1:4.

Зохих эрх мэдэл: Явж, бүх үндэстэнд зааж, Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр баптисм хүртээ, **Мат.** 28:19 (С ба Г 68:8). Лимхай мөн түүний хүмүүсийн олон нь баптисм хүртэх хүсэлтэй байв, гэвч уг нутагт Бурханаас эрх мэдэлтэй нь нэг ч байсангүй, **Моз.** 21:33. Баптисм хүртээх хүчийг би чамд өгье, **3 Ниф.** 11:19–21. Аароны санваартан нүглээс ангижралын баптисмын умбалтын түлхүүрүүдийг атгадаг, **С ба Г** 13:1. Тэд бол миний нэрээр баптисм хүртээхээр надаас томилогдсон тэд болой, **С ба Г** 18:29. Иосеф Смит, Оливер Каудери хоёрт баптисм хүртээх эрх мэдлийг Иохан Баптист өгчээ, **ИС—Т** 1:68–69.

Баптисмд тохирсон байх нь: Наманчлагтун та нар, мөн миний хайртай Хүүгийн нэрээр баптисм хүртэгтүн, **2 Ниф.** 31:11. Та нар наманчилж мөн дахин төрөх хэрэгтэй, **Алма** 7:14. Зохисгүйгээр баптисм хүртэхгүй байхаа мэд, **Морм.** 9:29. Эцэг эхчүүдэд тэд наманчилж мөн баптисм хүртэж өөрсдийгөө даруухан болгохыг заа, **Моро.** 8:10. Баптисм хүртэхийг хүсэгчдийн маяг танилцуулагдав, **С ба Г** 20:37. Хүүхдүүд найман нас хүрээд нүглийн ангижралын төлөө баптисм хүртэх ёстой, **С ба Г** 68:25, 27.

Баптисмаар дамжин хийгддэг гэрээнүүд: Та нар түүнд үйлчилж мөн түүний зарлигуудыг дагана хэмээх гэрээнд түүнтэй орлоо, **Моз.** 18:8–10, 13. Наманчилдаг, Христийн нэрийг авдаг, мөн түүнд үйлчлэхэд бэлэн хүн баптисм хүртээлтээр хүлээн авагдах болно, **С ба Г** 20:37.

Нас барагсдын төлөөх баптисм: Нас барагсдын төлөөх баптисм хүртэгч юу хийх ёстой вэ, **1 Кор.** 15:29. Нас

барагсдын төлөөх баптисмыг нүглийн ангижралын тулд гүйцэтгэдэг, **С ба Г** 124:29; 127:5–9; 128:1; 138:33.

Баптисм бага насны хүүхдүүдэд шаардлагагүй: Бяцхан хүүхдэд баптисм хүртээх нь Бурханы өмнөх хүнд элэглэл болдог, **Моро.** 8: 4–23. Хүүхдүүд найман нас хүрээд баптисм хүртэх ёстой, **С ба Г** 68:27. Хариуцлага хүлээх наснаас өмнө нас барсан бүх хүүхдүүд Селестиел хаант улсад аврагддаг болой, **С ба Г** 137:10.

БАПТИСТ. Иохан Баптистыг үз

БАРАБ

Есүсийг цовдлох үед түүний оронд суллагдсан хүний нэр. Бараб бол үймээн дэгдээгч, алуурчин, мөн хулгайч байжээ, (**Мат.** 27:16–26; **Марк** 15:6–15; **Лук** 23:18–25; **Иохан** 18:40).

БАРДАМНАЛ. Баялаг; Даруу,

Даруу байдал; Дэлхийн шинж чанар; Мөнгө; Хоосон, Хоосон чанарыг мөн үз

Даруу байдал буюу үг дуулан хүлээж авах явдал дутагдах. Бардамнал нь хүмүүсийг бие биенийх нь болон Бурханы эсрэг тавьдаг. Бардам хүн өөрийгөө эргэн тойрныхоо хүмүүсийн дээгүүр тавьж, Бурханы тааллаас илүүгээр өөрийн хүслийг дагадаг. Их зан, атаа жөтөө, хатуу сэтгэл, ихэмсэг байдал нь түүнчлэн бардам хүний хувьд хэвшмэл юм.

Зүрх сэтгэл чинь өргөгдсөн байхгүйн тулд Их Эзэнийг мартахаас чи болгоомжил, **Дэд хууль** 8:11–14. Бардамнал, ихэмсэг занг би жигшдэг, **Сур.** үгс 8:13 (Сур. үгс 6:16–17). Сүйрлийн өмнө бардам зан явдаг, **Сур.** үгс 16:18. Их Эзэний өдөр бардамнагчид дээр байх болно, **Иса.** 2:11–12 (2 Ниф. 12:11–12). Зүрхний чинь ихэрхэл чамайг хуурчээ, **Обад.** 1:3. Бүх бардамнагчид хожуул болох болно, **Малах.** 4:1 (1 Ниф. 22:15; 3 Ниф. 25:1; С ба Г 29:9). Өөрийгөө өргөмжлөгч нь дорд болгогдох

болно, **Мат.** 23:12 (С ба Г 101:42). Бурхан бардам хүнийг эсэргүүцдэг, **1 Петр** 5:5. Тэр агуу хийгээд нүсэр барилга нь дэлхийн бардамнал байв, **1 Ниф.** 11:36 (1 Ниф. 12:18). Тэд сураад өөрсдийгөө ухаантай хэмээн санадаг, **2 Ниф.** 9:28–29. Та нар зүрх сэтгэлийн бардамналд өргөгджээ, **Иаков** 2:13, 16 (Алма 4:8–12). Та нар бардамналаасаа ангижирсан уу? **Алма** 5:28. Хүмүүсийн зүрх сэтгэлд үлэмж агуу бардамнал нэвтэрчээ, **Хил.** 3:33–36. Хүмүүний үрс бардамналд хөөрөхдөө ямар хурдан бэ, **Хил.** 12:4–5. Энэ үндэстний бардамнал нь тэднийг сүйрэлд хүргэсээр буй, **Моро.** 8:27. Нифайчууд шиг болохгүйн тулд бардамналаас болгоомжил, **С ба Г** 38:39. Өөрсдийн бүхий л бардамнал хийгээд хөнгөн хуумгай явдлыг орхигтун, **С ба Г** 88:121.

БАРНАБ

Киприйн леви хүн Иосефт (түүнчлэн Хосе гэгддэг байв) өгсөн нэр, тэрээр газраа зараад мөнгийг нь Төлөөлөгчдөд өгчээ (Үйлс 4:36–37). Хэдийгээр анхны Арванхоёр Төлөөлөгчийн нэг биш боловч тэрээр Төлөөлөгч болж (Үйлс 14:4, 14) мөн хэд хэдэн номлолын аялалд үйлчилсэн байна (Үйлс 11:22–30; 12:25; 13–15; 1 Кор. 9:6; Гал. 2:1, 9; Кол. 4:10).

БАРТОЛОМЕЙ. Натанаелыг *мөн үз*

Шинэ Гэрээнд, Есүс Христийн анхны Арванхоёр Төлөөлөгчийн нэг (Мат. 10:2–4).

БАТШЕБА. Давидыг *мөн үз*

Уриагийн эхнэр; хожим нь Давидын эхнэр, Соломоны ээж болжээ. Давид хаан тэр эмэгтэйтэй садар самууныг үйлдэв. Тэрээр нөхрийнх нь үхлийг тулалдаанд тэрчлэн зохион байгуулж (2 Сам. 11), энэхүү нүгэл нь Давидын хувьд мөнхийн үр дагавруудыг авчирчээ, (С ба Г 132:39).

БАЯЛГУУД. Бардамнал; Мөнгийг

мөн үз

Эд баялаг буюу элбэг дэлбэг байдал. Дэлхийн баялгуудыг эрэлхийлэх биш, харин сайныг үйлдэхийг Их Эзэн Гэгээнтнүүдэд зөвлөдөг. Дэлхийн баялгуудыг эрэлхийлэх явдлыг Гэгээнтнүүд үүрд мөнхийн баялгуудыг эзэмшдэг Бурханы хаант улсыг эрэлхийлэхээс түрүүнд тавих ёсгүй (Иаков 2:18–19).

Баялгууд өсөж нэмэгдвэл тэдгээрт зүрх сэтгэлээ бүү тогтоо, **Дуул.** 62:10. Эд баялаг нь уур хилэнгийн өдөрт ямар ч тус болохгүй, **Сур. үгс** 11:4. Өөрийнхөө баялагт найдагч нэгэн унана, **Сур. үгс** 11:28. Сайн нэр агуу баялгаас ч эрхэм, **Сур. үгс** 22:1. Чинээлэг хүмүүс Бурханы хаанчлалд орох нь ямар хэцүү вэ, **Марк** 10:23 (Лук 18:24–25). Мөнгөний хайр бол бүх төрлийн бузар муугийн үндэс мөн, **1 Тим.** 6:10. Ядуусыг гадуурхдаг, мөн эд баялаг нь тэдний бурхан байдаг баячуудад халаг, **2 Ниф.** 9:30. Зөв шударгыг үйлдэгчид зүрх сэтгэлээ эд баялаг дээр тавьсангүй, харин бүхэнтэй хуваалцдаг байв, **Алма** 1:30. Эд баялгийнхаа улмаас хүмүүс бардам болж эхлэв, **Алма** 4:6–8. Эд баялгийнхаа дагуу хүмүүс зэрэг зиндаагаар ялгарч байв, **3 Ниф.** 6:12. Эд баялгийг биш, харин мэргэн ухааныг эрэлхийл, **С ба Г** 6:7 (Алма 39:14; С ба Г 11:7). Дэлхийн баялгуудыг өгөх нь Бурханых билээ, гэвч бардамналаасаа болгоомжил, **С ба Г** 38:39.

Үүрд мөнхийн баялгууд: Тэнгэрт эд баялгийг хураа, **Мат.** 6:19–21. Мөнх амьдралын эд баялгуудаар би та нарыг хичнээн ч удаа дуудсан билээ, **С ба Г** 43:25. Үүрд мөнхийн баялгуудыг өгөх нь минийх бөлгөө, **С ба Г** 67:2 (С ба Г 78:18).

БАЯР БАЯСАЛ. Дуулгавартай,

Дуулгавартай байдал,

Дуулгавартай дагахыг *мөн үз*

Агуу аз жаргалын нөхцөл нь зөв шударга амьдрахаас ирдэг. Мөнх

бус амьдралын зорилго бол бүх хүмүүс баяр баясалтай байх явдал юм (2 Ниф. 2:22–25). Бүрэн баясал нь зөвхөн Есүс Христээр дамжиж ирэх болно (Иохан 15:11; С ба Г 93:33–34; 101:36).

Даруу нэгний баяр хөөр ЭЗЭНий дотор өсөн нэмэгджээ, **Иса.** 29:19 (2 Ниф. 27:30). Агуу баяр хөөрийн сайн мэдээг би та нарт авчирлаа, **Лук** 2:10. Та нарын баяр баясгаланг хэн ч та нараас булаахгүй, **Иохан** 16:22. Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар амгалан мөн, **Гал.** 5:22. Үүний үр жимс миний сэтгэлийг үлэмж агуу баяр хөөрөөр дүүргэв, **1 Ниф.** 8:12. Тэд баяр баясгалантай байж болохын тулд хүмүүн байдаг бөлгөө, **2 Ниф.** 2:25. Зөв шударгыг үйлдэгчдийн баяр үүрд бялхаж байх болно, **2 Ниф.** 9:18. Тэд Бурхантай хамт хэзээ ч төгсөшгүй аз жаргалын байдалд оршиж болох буюу, **Моз.** 2:41. Би энэхүү агуу их баяслыг хүлээн авч болохын тулд би эзэмшдэг бүхнээ өгөх болно, **Алма** 22:15. Зарим бодгалиудыг наманчлалд авчрахад би Бурханы мутар дахь зэмсэг байж болох ажгуу, мөн энэ нь миний баясал бөлгөө, **Алма** 29:9. Ямар баясал, мөн ямар гайхамшигт гэрлийг болгоосон билээ би, **Алма** 36:20. Миний Сүнс та нарын сүнсийг баяслаар дүүргэх болно, **С ба Г** 11:13. Миний Эцэгийн хаант улсад түүнтэй хамт эдлэх та нарын баяр хөөр хичнээн агуу билээ, **С ба Г** 18:15–16. Энэ дэлхийд та нарын баясал бүрэн биш, харин надад та нарын баясал бүрэн болой, **С ба Г** 101:36. Энэ амьдралд би баяр хөөртэй байх болно, **Моисе** 5:10–11.

БЕЛШААЗАР. Бабел, Вавилоныг
мөн үз

Хуучин Гэрээнд Вавилоныг Перс эзлэхээс өмнө Вавилонд хаанчилж байсан сүүлчийн хаан; Небухаднезарын хүү болон өв залгамжлагч (Дан 5:1–2).

БЕНЖАМИН, МОЗАЯГИЙН

ААВ. Мозая, Бенжамины хүүг
мөн үз

Мормоны Номын бошиглогч мөн хаан (Моз. 1–6).

Газар нутагтаа энх тайвныг тогтоохын тулд ноцтой асуудлуудтай тулгаран шийдвэрлэж байв, **Омнаи** 1:23–25 (Мор.үгс 1:12–18). Хүүхдүүд дээ заасан, **Моз.** 1:1–8. Өөрийн хүү Мозаяд хаант улсаа хүртээжээ, **Моз.** 1:9–18. Түүний хүмүүс түүний сүүлчийн үгийг сонсохоор цугларчээ, **Моз.** 2:1–8. Хүмүүстэй хандан ярьсан, **Моз.** 2:9–4:30. Түүний хүмүүс Их Эзэнтэй гэрээ байгуулсан байна, **Моз.** 5–6.

БЕНИАМИН, ИАКОВЫН ХҮҮ.

Иаков; Исаакийн хүү;
Израилыг *мөн үз*

Хуучин Гэрээнд Иаков, Рахел нарын хоёр дахь хүү (Эхл. 35:16–20).

Бениамины овог: Иаков Бениаминыг адислав (Эхл. 49:27). Бениамины удмынхан дайчин үндэстэн байлаа. Бениаминчуудын хоёр чухал хүн бол израилчуудын анхны хаан Саул (1 Сам. 9:1–2), мөн Шинэ Гэрээний Төлөөлөгч Паул хоёр байв (Ром 11:1).

БЕТАН

Мөнх бус амьдралынхаа сүүлчийн долоо хоногийн үеэр Есүс Христийн байсан тосгон (Мат. 21:17; Марк 11:11). Чидуны Уулын бэл дэх Бетан нь Лазар, Мариа, Марта нарын нутаг юм (Иохан 11:1–46; 12:1).

БЕТЕЛ

Еврей хэлний “Бурханы гэр” гэсэн утгатай үг бөгөөд Израилын хамгийн ариун нандин газруудын нэг. Энэ нь Иерусалимаас ойролцоогоор арван зургаан километрийн зайд оршдог. Анх удаа Канаанд ирэхдээ Абрахам энд тахилынхаа ширээг барьсан ажээ (Эхл. 12:8; 13:3). Энд Иаков тэнгэр өөд өгсөж буй шат харсан үзэгдлээ үзжээ (Эхл.

28:10–19). Энэ нь мөн Самуелын өдрүүдийн ариун газар байв (1 Сам. 7:16; 10:3).

БЕТЛЕХЕМ

Иерусалимаас урагш таван бээрт байдаг жижигхэн хот. Еврей хэлэнд Бетлехем гэдэг нь “талхны гэр” гэсэн утгатай бөгөөд энэ нь тэрчлэн “үр жимстэй” гэсэн утгатай Ефрат хэмээн нэрлэгддэг. Есүс Христ Бетлехемд төржээ (Мика 5:2; Мат. 2:1–8). Энэ нь Рахелыг оршуулсан газар юм (Эхл. 35:19; 48:7).

Рут Боаз хоёр энд амьдарч байжээ, **Рут** 1:22. Самуел Давидыг тэнд төсөв, **1 Сам.** 16:1–13; 17:12, 15; 20:6, 28. Херод тэнд хүүхдүүдийг алжээ, **Мат.** 2:16.

БИ БАЙДАГ. Есүс Христ; Иеховаг
мөн үз

Их Эзэн Есүс Христийн нэг нэр.

БИ БАЙДАГ гэдэг нь БИ билээ хэмээн Бурхан Мосед айлдав, **Ег.** 3:14–15. Би бол Эзэн, **Ег.** 6:2–3. Абрахамыг бий болохоос өмнө Би Байдаг байсан, **Иохан** 8:56–59. Есүс Христ, Агуу Би Байдагийн дуу хоолойг сонсогтун, **С ба Г** 29:1 (38:1; 39:1).

БИБЛИ. Апокриф; Ефраим—
Ефраим буюу Иосефын саваа;
Иудей—Иудейн саваа; Канон;
Хуучин Гэрээ; Шинэ Гэрээг
мөн үз

Тэнгэрлэг илчлэлтүүдийг багтаасан Еврейн болон Христийн шашинтны бичээсүүдийн цуглуулга. “Библи” гэсэн нь “номнууд” гэсэн утгатай. Библи бол олон бошиглогчдын хийгээд Ариун Сүнсний нөлөөлөл дор өдөөгдсөн бичээсүүд юм (2 Петр 1:21).

Христийн шашинтны Библи нь нийтээр мэдэх Хуучин ба Шинэ Гэрээ гэсэн хоёр хэсэгтэй. Хуучин Гэрээ нь Их Эзэний мөнх бус тохиууллын үед Палестины иудейчүүд дунд хэрэглэгдэж байсан суд-

рын номнуудыг багтаадаг. Шинэ Гэрээ нь Төлөөлөгчдийн үеийн еврей судартай адил цэвэр ариун хийгээд эрх мэдэл бүхий бичээсүүдийг агуулдаг. Хуучин Гэрээний номнуудыг олон зууны турш үндэсний утга зохиолоос түүвэрлэн авсан бөгөөд энэ нь бараг бүгдээрээ еврей хэлээр бичигдсэн байхад Шинэ Гэрээний номнууд нь зөвхөн нэг л үеийнхний ажил бөгөөд ихэвчлэн грек хэлээр бичигджээ.

Хуучин Гэрээний *гэрчлэл* гэсэн үг нь “гэрээ” гэсэн утгатай еврей үгийг төлөөлдөг. Хуучин Гэрээ бол мөнх бус байдлын эхлэлээс Бурханы хүүхдүүдэд байсан сайн мэдээний бүрэн байдлыг израилчууд эсэргүүцэх үед Мосед өгөгдсөн хууль юм. Шинэ Гэрээ бол Есүс Христээр заагддаг сайн мэдээ юм.

Еврей Библид (Хуучин Гэрээ) номнууд нь: Хууль, Бошиглогчид, Бичээсүүд гэсэн гурван хэсэгт хуваагддаг. Христийн ертөнцийн ашигладаг Библи нь номнуудыг түүхийн, яруу найргийн, бошиглолын гэхчлэн эсвдийн асуудлын дагуу ангилдаг.

Шинэ Гэрээний номнууд нь ерөнхийдөө дараах дэс дараалалтай байдаг: Дөрвөн Сайн мэдээ ба Үйлс; Паулын захидлууд; Иаков, Петр, Иохан болон Иудагийн ерөнхий захидлууд; түүнчлэн Иоханы Илчлэл.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм Библийг эрхэмлэн дээдлэхийн хамт хүмүүн төрөлхтөнтэй харьцсан Бурханы үйл хэргүүдийн талаарх Библийн шастирыг нотлон дэмжихийн тулд Их Эзэн эцсийн өдрүүдэд өөрийн бошиглогчдоор дамжуулан нэмэлт илчлэлтүүд өгөхөө үргэлжлүүдлийг тэрчлэн баталдаг билээ.

Иудейн саваа (Библи) мөн Иосефын саваа (Мормоны Ном) хоёр Их Эзэний гарт нэг болно, **Езек.** 37:15–20. Библийн үнэн байдал хожмын үеийн судруудаар бий болгодоно, **1 Ниф.** 13:38–40. Библи Мормоны

номтой нэгдэн буруу сургаалыг бүрмөсөн үгүйсгэх болно, **2 Ниф.** 3:12. Библи, Библи, бидэнд Библи бий, **2 Ниф.** 29:3–10. Библид итгэх хүн бүхэн Мормоны Номонд мөн итгэх болно, **Морм.** 7:8–10. Ахлагч нар Библи болон Мормоны Номон дахь миний зарчмуудыг заах болно, **С ба Г** 42:12. Библи нь зөв орчуулагдахын хэрээр Бурханы үг мөн гэдэгт бид итгэдэг **ИТ** 1:8.

БИБЛИ, ИОСЕФ СМИТИЙН ОРЧУУЛГА (ИСО). Иосеф Смитийн Орчуулгыг (ИСО) үз

БИЕ. Амилуулалт; Биеийн Үхэл; Бодгаль; Мөнх бус, Мөнх бус байдлыг *мөн үз*

Амьд хүнийг бий болгохын тулд Бурханы дүр төрхөөр сүнстэй нэгтгэгдсэн, мах болон ясан бүтэц бүхий мөнх бус бие. Амилуулалтаар бүх эрэгтэй хийгээд эмэгтэй хүмүүсийн бие махбодь сүнснүүдтэйгээ мөнхөд нэгдэх болно. Бие болон сүнс хамтдаа нэгдсэнийг сударт заримдаа бодгаль хэмээн нэрлэдэг (Эхл. 2:7; С ба Г 88:15; Мосе 3:7, 9, 19; Абр. 5:7)

Их Эзэн Бурхан тоос шорооноос хүнийг бүтээв, **Эхл.** 2:7 (Мосе 3:7). Надад гараа хүргээд үз, учир нь сүнсэнд яс, мах байдаггүй юм, **Лук** 24:39. Би биеэ захирч мөн нөхцөлд авчирдаг, **1 Кор.** 9:27. Төрөлх бие байдаг бол, сүнслэг бие ч байдаг, **1 Кор.** 15:44. Сүнсгүй бие үхмэл байдаг, **Иаков** 2:26. Мөнх бус бие мөнх бие болон босож ирнэ, **Алма** 11:43–45. Биеийн хэсэг болгон сэргээгдэх болно, **Алма** 41:2. Есүс өөрийн амилсан биеийг нифайчуудад үзүүлжээ, **3 Ниф.** 10:18–19; 11:13–15. Эцэг яг хүмүүний адил мэдрэгдэх мах хийгээд ясан биетэй, мөн Хүү ч бас адил бөлгөө, **С ба Г** 130:22. Бурхан эрэгтэй эмэгтэй хүнийг өөрийнхөө биеийн дүрээр бүтээжээ, **Мосе** 6:9 (Эхл. 9:6).

БИЕИЙН ҮХЭЛ. Аврал; Адам Ева хоёрын Уналт; Амилуулалт;

Мөнх бус, Мөнх бус байдлыг *мөн үз*

Бие болон сүнсний салалт. Уналт нь мөнх бус байдал болон үхлийг дэлхий дээр авчирчээ (2 Ниф. 2:22; Мосе 6:48). Есүс Христийн цагаатгал үхлийг ялан дийлснээр хүн бүр амилуулагдах болно (1 Кор. 15:21–23). Амилуулалт нь энэ амьдралд сайн буюу муу алиныг ч хийсэнд бүгдэд үнэгүй бэлэг болой (Алма 11:42–44). Хүн бүхэн зөвхөн ганц бие махбодийн үхлээр үхэх бөгөөд бидний бие махбодь дахин үхэхгүй болой (Алма 11:45).

Бүх махан бие үхэж мөн хүн шороонд буцах болно, **Иов** 34:15. Өөрийнх нь Гэгээнтнүүдийн үхэл Их Эзэний мэлмийд үнэ цэнэтэй, **Дуул.** 116:15. Тоос нь шороондоо буцаж, мөн сүнс нь Бурханд буцан очно, **Номло.** үгс 12:7. Хүмүүнээр үхэл ирсэн, **1 Кор.** 15:21. Аврагч үхлийн болон тамын түлхүүрүүдийг атгадаг, **Илч.** 1:18. Тэнд үхэл ч, бас гашуудал ч дахин байхгүй байх болно, **Илч.** 21:4. Үхэл бүх хүмүүн дээр улиран ирнэ, **2 Ниф.** 9:6, 11 (Алма 12:24). Тэд үхлийг ямар нэгэн аймшиг хэмээн бодохоо больсон, **Алма** 27:28. Алма үхэл болон амилуулалтын хоорондох сүнсний байдлын талаар тайлбарлав, **Алма** 40:11. Надад нас барсан тэр нь үхлийг үл амсах болой, **С ба Г** 42:46. Үхэлд оногдоогүй тэр нь эдгэрэх болно, **С ба Г** 42:48. Би та нарыг бүх зүйлд, бүр үхэлд ч нотлох болно, **С ба Г** 98:14. Шороонд чи буцаж очих болно, **Мосе** 4:25. Адам унасан, мөн түүний уналтаар үхэл ирсэн бөлгөө, **Мосе** 6:48.

БИШОП. Аароны санваарыг *мөн үз*

“Харгалзагч” гэсэн утгатай үүрэг хариуцлагын албан тушаал буюу байр суурь. Бишоп бол Аароны санваарт томилогддог албан тушаал (С ба Г 20:67; 107:87–88), бөгөөд бишоп нь Израилд ерөнхий шүүгч байдаг (С ба Г 107:72, 74).

Ариун Сүнс чамайг харгалзагч болгосон юм, **Үйлс** 20:28. Бишопын эрх мэдэл танилцуулагдав, **1 Тим.** 3:1–7 (Тит 1:7). Бишоп бол томилогддог, **С ба Г** 20:67. Эдвард Партриж Сүмд бишопоор үйлчлэх ёстой, **С ба Г** 41:9. Бишоп сүнслэг бэлгүүдийг ялгах ёстой, **С ба Г** 46:27, 29. Дээд санваартан нь бишопын албан тушаалыг гүйцэтгэж болно, **С ба Г** 68:14, 19 (С ба Г 107:17). Бишоп нь Их Эзэнээс томилогддог, **С ба Г** 72:1–26. Бишоп ядуусыг халамжлах ёстой, **С ба Г** 84:112. Бишоп бүх цаг зуурын зүйлсийг гүйцэтгэх ёстой, **С ба Г** 107:68. Бишоп нь Аароны санваартны ерөнхийлөгч юм, **С ба Г** 107:87–88.

БИШРЭН ШҮТЭХ. Бурхан, Бурхан Тэргүүтнийг *мөн үз*

Бурханыг хайрлаж, хүндэтгэн, үйлчилж мөн бишрэн шүтэх (С ба Г 20:19). Бишрэн шүтэхэд залбирал, мацаг, сүмийн үйлчлэл, сайн мэдээний ёслолуудад хийгээд Бурханд хайр болон бишрэлээ харуулах бусад зүйлүүдэд оролцох нь багтдаг.

Чи надаас өөр бурхадтай байж болохгүй, **Ег.** 20:3 (Ег. 3:21–8, 19–35; Дуул. 81:9). Эцэгт сүнсээр хийгээд үнэнээр мөргө, **Иохан** 4:23. Тэнгэр хийгээд газрыг бүтээсэн түүнд мөргөцгөө, **Илч.** 14:7 (С ба Г 133:38–39). Түүнийг өөрсдийн бүхий л хүчин чадал, оюун, мөн чадлаараа бишрэн шүт, **2 Ниф.** 25:29. Тэд Христэд итгэж, мөн түүний нэрээр Эцэгийг бишрэн шүтэж байв, **Иаков** 4:5. Хүн бүх газруудад залбирч мөн шүтэн бишрэх ёстой хэмээн Зенос заав, **Алма** 33:3–11. Байж болох газар бүртээ Бурханыг сүнсэнд бас үнэнд шүтэн бишрээсэй, **Алма** 34:38. Хүмүүс Есүсийн хөлд унаж мөн түүнийг шүтэн биширчээ, **3 Ниф.** 11:17. Бүх хүмүүн наманчилж, Есүс Христэд итгэн, мөн Эцэгийг түүний нэрээр шүтэн бишрэх ёстой, **С ба Г** 20:29. Мөн та нар хэрхэн бишрэн шүтэхийг, мөн та нар юуг бишрэн шүтэхийг ойлгож мөн мэдэж боло-

хын тулд эдгээр айлдваруудыг би та нарт өгч байна, **С ба Г** 93:19. Зөвхөн энэ Бурханыг л би шүтэн бишрэх болно, **Моце** 1:12–20. Бүхнийг Чадагч Бурханыг бид шүтэн бишрэх эрхтэй, **ИТ** 1:11.

БОАЗ. Рутыг *мөн үз*

Рутын нөхөр (Рут 4:9–10); Израилын хаан Давидын өндөр өвөг эцэг (Рут 4:13–17); мөн Хаадын Хаан Христийн элэнц өвөг юм (Лук 3:32).

БОДГАЛЬ. Бие; Сүнсийг *мөн үз*

Судрууд бодгалийн тухай гурван янзаар өгүүлдэг: (1) Мөнх бус амьдралын өмнөх хийгээд мөнх бус амьдралын дараах сүнсэн биес (Алма 40:11–14; Абр. 3:23); (2) Мөнх бусад нэгдсэн сүнс ба бие (Абр. 5:7); түүнчлэн (3) сүнс хийгээд бие нь дахин салшгүйгээр холбогдсон үхэшгүй, амилуулагдсан хүн (Алма 40:23; С ба Г 88:15–16).

Цус бол амийн төлөө эвлэрүүллийг хийдэг, **Лев.** 17:11. Тэр миний сэтгэлийг сэргээдэг (амийг дахин сэргээнэ), **Дуул.** 23:3. Чи бүх зүрх сэтгэлээрээ Их Эзэн Бурханаа хайрла, **Мат.** 22:37 (Марк 12:30). Чөтгөр тэдний бодгалийг хуурдаг, **2 Ниф.** 28:21. Өөрийн бүх бодгалиа түүнд өргөл болгон өргө, **Омнаи** 1:26. Үг нь миний бодгалийг өсгөж эхэлдэг, **Алма** 32:28. Түүний бодгаль хэзээ ч өлсөж мөн цангахгүй, **3 Ниф.** 20:8. Ариун ёслолын талх болон ус нь түүнийг хүртэх бодгалийг ариусгадаг, **Моро.** 4–5 (С ба Г 20:77–79). Хаант улс дахь хөдөлмөрлөгчид үйлчлэлээр дамжуулан өөрсдийнхөө бодгальд авралыг авчирна, **С ба Г** 4:2, 4. Бодгалийн үнэ цэнэ агуу юм, **С ба Г** 18:10. Чи дэлхийд ус, цус мөн сүнсээр төрж мөн амьд махбодь болсон бөлгөө, **Моце** 6:59.

Бодгалийн үнэ цэнэ: Бүх хүн Бурханы сүнсэн хүүхдүүд. Тэрээр өөрийн хүүхэд бүрийн талаар анхааран халамжилж мөн бүгдийг нь чухалд тооцдог. Тэд түүний хүүхдүүд

учраас түүнтэй адил болох боломж тэдэнд бий. Тийм учраас, тэд бол агуу үнэ цэнэтэй юм.

Нэг нүгэлтэн наманчлахад баяр хөөр болно, **Лук** 15:10. Бурхан дэлхийг үнэхээр хайрласан тул Төрсөн Ганц хүүгээ өгсөн бөлгөө, **Иохан** 3:16. Тэд аль ч хүмүүний бодгаль мөхнө гэдгийг тэвчиж үл чадах байлаа, **Моз.** 28:3. Бурханд энэ үеийн бодгаль түүний ирэлтийн үед байх бодгалийн адил эрхэм бус уу? **Алма** 39:17. Чамд хамгийн үнэтэй зүйл бол бодгалийг надад авчрах нь болой, **С ба Г** 15:6. Бодгалиудын үнэ цэнэ Бурханы мэлмийд агууг сана, **С ба Г** 18:10–15. Хүмүүнд үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө, **Моце** 1:39.

БОДОЛ САНАА. Сонгох эрх;
Тунгаан бодохыг мөн үз

Хүний оюун дахь санаа, үзэл баримтлал хийгээд төсөөлөл. Бодох хүч нь Бурханы бэлэг бөгөөд бодох хүчээ хэрхэн ашиглахыг сонгох талаар бид чөлөөтэй байдаг. Бид хэрхэн сэтгэн бодох нь харьцаа хандлага хийгээд зан төлөв, түүнчлэн энэ амьдралын дараах бидний байдалд ихээр нөлөөлнө. Зөв шударга бодол санаа аврал уруу хөтөлнө; ёс бус бодол санаа ял уруу хөтөлдөг.

ЭЗЭН бүх бодол санааны хандлагуудыг мэддэг, **Шаст.** дээд 28:9. Тэрээр дотроо боддогтойгоо адил юм, **Сур.** үгс 23:7. Миний бодол чиний бодол биш, **Иса.** 55:7–9. Есүс тэдний бодлыг мэдэж байв, **Мат.** 12:25 (**Лук** 5:22; 6:8). Дотроос, хүмүүсийн зүрхнээс хорон муу бодол гардаг, **Марк** 7:20–23. Ямарч бодол санааг Христийн дуулгавартай байдалд олзлуулдаг, **2 Кор.** 10:5. Юу үнэн, хүндэтгэлтэй, зөв, цэвэр ариун, сайхан байна, эдгээр зүйлсийг бод, **Филип.** 4:8. Биеэ бодох нь үхэл, мөн сүнсээ бодох нь мөнхийн амьдрал гэдгийг сана, **2 Ниф.** 9:39. Хэрэв та нар өөрсдийгөө, мөн өөрсдийн бодлуудаа,

мөн үгсээ, мөн үйлүүдээ хянахгүй аваас мөхөх болно, **Моз.** 4:30. Бодлууд маань биднийг буруутгах болно, **Алма** 12:14. Зөвхөн Бурхан л зүрхний чинь хүсэл бодлуудыг мэддэг, **С ба Г** 6:16 (**С ба Г** 33:1). Бүх бодлуудаа над руу хар, **С ба Г** 6:36. Амьдралын үгсийг оюундаа нөөцөл, **С ба Г** 84:85. Хэрэггүй бодлуудаа авч хая, **С ба Г** 88:69. Хүмүүний зүрхний бодлууд илчлэгдэх болно, **С ба Г** 88:109. Ариун нь чиний бодлыг зогсолтгүйгээр тэжээг, **С ба Г** 121:45. Хүн болгон үргэлжид хилэнцэт буюу, **Моце** 8:22.

БООЛЧЛОЛ. Эрх Чөлөө; Эрх чөлөөтэйг мөн үз

Бие бялдрын буюу сүнсний боолчлолд байх.

Израилын гэр өөрсдийнхөө алдсын улмаас дарангуйлалд орсон, **Езек.** 39:23. Дарангуйлалд хөтөлдөг тэр нь дарангуйлалд явах болно, **Илч.** 13:10. Ёсон бус нь чөтгөрийн боолчлолд доош авчирдаг, **1 Ниф.** 14:4, 7. Хүмүүн эрх чөлөө ба мөнх амьдрал, эсвээс боолчлол болон үхлийг сонгох эрхтэй, **2 Ниф.** 2:27. Маханбодийн хүсэл чөтгөрийн сүнсэнд боолчлох хүчийг өгдөг, **2 Ниф.** 2:29. Та нар өөрсдийн эцэг өвгөдийн боолчлолыг хангалттайгаар санасаар байдаг уу? **Алма** 5:5–6. Зүрх сэтгэлээ хатууруулах тэд чөтгөрийн боолчлолд аваачигддаг, **Алма** 12:11. Чөтгөрөөр уруу татагдаж түүгээр боолчлогдон удирдагдахгүйн тулд та нар үргэлж сэрэмжилж мөн залбирах ёстой, **3 Ниф.** 18:15.

БОШИГ ЛОГЧ, ЭШ ҮЗҮҮЛЭГЧ.

Бошиглол, Бошиглох;
Ерөнхийлөгч; Илчлэлт;
Үзмэрчийг мөн үз

Бурханаар дуудагдаж, түүний өмнөөс ярьдаг хүн. Бошиглогч нь Бурханы элчийн хувьд Бурханаас ирдэг зарлигууд, бошиглолууд хийгээд илчлэлтүүдийг хүлээн авдаг. Түүний үүрэг хариуцлага бол Бурханы хүсэл зориг хийгээд үнэн

мөн чанарыг хүн төрөлхтөнд таниулж, тэдэнтэй ажиллах явдлын утга учрыг харуулах явдал мөн. Бошиглогч нүглийг буруушаан зэмлэж, үр дагавруудыг нь угтан хэлдэг. Бошиглогч бол зөв шударга ёсыг номлогч мөн. Зарим тохиолдолд бошиглогчид хүн төрөлхтний ашиг тусын тулд ирээдүйг угтан хэлэхэд сүнслэгээр нөлөөлөгддөг байна. Гэвч түүний анхдагч үүрэг хариуцлага бол Христийн тухай гэрчлэх явдал мөн. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгч бол өнөөдөр дэлхий дээрх Бурханы бошиглогч мөн. Тэргүүн Зөвлөлийн гишүүд болон Арванхоёр Төлөөлөгч нь бошиглогчид, үзмэрчид, илчлэгчдээр дэмжин батлагддаг.

ЭЗЭНий бүх хүмүүсийг Бурхан эш үзүүлэгчид болгодог болоосой, **Тоол. 11:29.** Хэрэв эш үзүүлэгч байх аваас ЭЗЭН би өөрийгөө түүнд үзэгдлээр мэдүүлэх болно, **Тоол. 12:6.** ЭЗЭН бүх бошиглогчдоор дамжуулан Израилын эсрэг гэрчлэв, **Хаад. дэд 17:13** (Шаст. дэд 36:15–16; Иер. 7:25). Би чамайг үндэстнүүдэд бошиглогчоор томилсон, **Иер. 1:5.** 7. Тэрээр нууцаа өөрийн үйлчлэгч бошиглогчдод илчилдэг, **Амос 3:7.** Тэрээр өөрийн ариун бошиглогчдын амаар ярив, **Лук 1:70** (Үйлс 3:21). Бүх бошиглогчид Христийн тухай гэрчилдэг байв, **Үйлс 10:43.** Бурхан Сүмд бошиглогчдыг тавьжээ, **1 Кор. 12:28** (Еф. 4:11). Төлөөлөгчид хийгээд бошиглогчдын суурин дээр Сүм баригдсан, **Ефес 2:19–20.** Хүмүүс бошиглогчдын үгсийг эсэргүүцэв, **1 Ниф. 3:17–18** (2 Ниф. 26:3). Бүх зүйл Сүнсээр бошиглогчдод мэдүүлэгддэг, **1 Ниф. 22:1–2.** Өөрийн ариун бошиглогчдын амаар хэлсэн бүхнээ гүйцэлдүүлэхийн тулд Христ нифайчууд дээр иржээ, **3 Ниф. 1:13** (С ба Г 42:39). Бошиглогчдын үгст анхаарал эс тавих тэд туслгаарлагдах болно, **С ба Г 1:14.** Бошиглогчдын үгст итгэдэг тэд мөнх амьдралыг авна, **С ба Г 20:26.** Та на-

рын хүлээж авах бошиглогчийн үг нь миний өөрийн амнаас лугаа адил болой, **С ба Г 21:4–6.** Сүмд зориулсан илчлэлтүүд хийгээд зарлигууд нь зөвхөн томилогдсон нэгнээр дамжин ирдэг билээ, **С ба Г 43:1–7.** Ерөнхийлөгчийн үүрэг нь нийт Сүмийг тэргүүлэх хийгээд Мосегийн адил бошиглогч байх явдал мөн, **С ба Г 107:91–92.** Бид бошиглогчдод итгэдэг, **ИТ 1:6.**

БОШИГЛОГЧ ЭМЭГТЭЙ.

Бошиглол, Бошиглохыг мөн үз

Есүс Христийн тухай гэрчлэлийг хүлээн авч мөн илчлэлтийн сүнснийг эзэмшдэг эмэгтэй хүн. Эмэгтэй бошиглогч санваарыг буюу үүний түлхүүрүүдийг атгадаггүй. Судруудад ердөө хэдхэн эмэгтэй бошиглогч хэмээн нэрлэгдсэн байдаг хэдий ч, Ребека, Ханна, Елизабет, Мариа гэхчлэн олон нь бошиглож байв.

Мириам эмэгтэй бошиглогчоор дуудагдсан байв, **Ег. 15:20.** Дебора эмэгтэй бошиглогчоор дуудагдсан байв, **Шүүгч. 4:4.** Хулда эмэгтэй бошиглогчоор дуудагдсан байв, **Хаад. дэд 22:14** (Шаст. дэд 34:22). Анна эмэгтэй бошиглогчоор дуудагдсан байв, **Лук 2:36.**

БОШИГЛОГЧДЫН СУРГУУЛЬ.

Бага Иосеф Смитийг мөн үз

1832–1833 оны өвөл Көртландын Огайод (Америкийн Нэгдсэн Улс) Бурханы хаант улс хийгээд сайн мэдээтэй холбоотой бүх зүйлийг ах нарт сургах зорилгоор сургууль зохион байгуулахыг Их Эзэн Иосеф Смитэд зарлиглажээ. Энэ сургуулиас Сүмийн анхны олон удирдагч гарч ирсэн юм. Бошиглогчдын буюу ахлагчдын өөр нэгэн сургууль Миссурийн Жаксон гүнлэгт Парлей П.Пратгаар удирдуулж байв (С ба Г 97:1–6). Өрнөдөг Гэгээнтнүүд нүүж ирсний дараахан үүнтэй адил сургууль хичээллэж байсан хэдий ч, удалгүй зогсжээ. Өнөөдөр сайн

мэдээг гэртээ, санваартны чуулгууд, түүнчлэн хавсралт байгууллагууд мөн Сүмийн сургуулиуд болон семинар, институтын ангиудаар дамжуулан заадаг.

Өөрсдийгөө ариусга, мөн бие биендээ хаант улсын сургаалуудыг заа, **С ба Г 88:74–80**. Хичээнгүйлэн хай, мөн бие биендээ заа, **С ба Г 88:118–122**. Бошиглогчдын сургуулийн журам бий болов, **С ба Г 88:127–141**. Тэргүүн Зөвлөл бошиглогчдын сургуулийн түлхүүрүүдийг атгадаг, **С ба Г 90:6–7**.

БОШИГЛОЛ, БОШИГЛОХ.

Бошиглогч, Бошиглогч эмэгтэй;
Илчлэлт, Үзмэрчийг *мөн үз*

Бошиглол нь илчлэлтээр дамжуулан Ариун Сүнснээс хүлээн авдаг сүнслэгээр нөлөөлөгдсөн үгс болон бичээсүүдээс бүрддэг. Есүсийн тухай гэрчлэл бол бошиглолын сүнс мөн (Илч. 19:10). Бошиглол нь өнгөрсөн, одоо, ирээдүйг хамарч болно. Хүн бошиглохдоо өөрийнх нь сайн сайхны буюу бусдын сайн сайхны тулд Бурханаас түүнд мэдүүлэхийг хүссэн зүйлийг тэрээр ярих буюу бичдэг. Хувь хүмүүс амьдралынхаа талаар бошиглол буюу илчлэлтийг хүлээн авч болно.

ЭЗЭН бүх ард түмнийг эш үзүүлэгчид болгодог болоосой, **Тоол. 11:29**. Та нарын хөвгүүд, охид эш үзүүлэх болно, **Иоел 2:28** (Үйлс 2:17–18). Тэрээр өөрийн нууцыг үйлчлэгчид эш үзүүлэгчиддээ илчилдэг, **Амос 3:7**. Судрын нэг ч эш үзүүлэгч эш үзүүлэгчийн өөрийнх нь тайлбараар ирээгүй, **2 Петр 1:20**. Нифайчууд олон бошиглол хийгээд бошиглолын сүнсстэй байв, **Иаков 4:6, 13**. Алма, Амюлек хоёр Зиезромын зүрхний бодлуудыг бошиглолоор мэджээ, **Алма 12:7**. Их Эзэн бошиглолоор ажиллахаа больсон хэмээн хэлдэг түүнд халаг, **3 Ниф. 29:6**. Исаиагийн бошиглолуудыг судал, **Морм. 8:23**. Бошиглолууд бүгдээрээ биелэгдэх болно, **С ба Г 1:37–38**.

Хүмүүс Бурханаас бошиглолоор дуудагдах ёстой, **ИТ 1:5**.

БУЗАР, БУЗАР БУЛАЙ ЯВДАЛ.

Бурханлиг бус; Ёс бус; Ёс бус явдал; Зөв шударга бус; Зөв шударга бус явдал; Нүгэл; Цэвэр ба Цэвэр бусыг *мөн үз*

Бурханд зориудаар дуулгаваргүй байсны улмаас ирдэг сүнсний цэвэр ариун биш байдал.

Эзэн Сионы охидын бузрыг угаан арилгах болно, **Иса. 4:4** (2 Ниф. 14:4). Бурханы хаант улс бол бузар биш, **1 Ниф. 15:34** (Алма 7:21). Бузар тэд бузар хэвээрээ байх болно, **2 Ниф. 9:16** (Морм. 9:14). Өмсгөлүүд тань бузар муухайгаар толботсон байдалтайгаар та нар Бурханы тавцангийн өмнө зогсох болбол та нарт ямар санагдах вэ? **Алма 5:22**. Тэд бузар хэвээр үлдэх ёстой, **С ба Г 88:35**. Хэзээ би амарч, мөн бузар муугаас цэвэрших билээ? **Моце 7:48**.

БУЛШ. Амилуулалтыг *мөн үз*

Мөнх бус биеийг оршуулах газар. Цагаатгалын учир, хүн бүр булнаас амилуулагдах болно.

Христийн амилалтын дараа, булшнууд нээгдэж, олон биес боссон билээ, **Мат. 27:52–53** (3 Ниф. 23:9–13). Үхэл ээ, чиний ялалт хаана байна вэ! **1 Кор. 15:55**. Булш өөрсдийнхөө нас нөгцөгчийг чөлөөлөх ёстой, **2 Ниф. 9:11–13**. Булшинд нойрссон тэд урагш гарч ирэх болно, **С ба Г 88:97–98**. Багтисмын сан бол булшны бэлэгдэл мөн, **С ба Г 128:12–13**.

БУРУУТГАЛ, БУРУУТГАХ.

Шүүлт, Шүүх; Эцсийн шүүлтийг *мөн үз*

Шүүх буюу гэм буруутай хэмээн Бурханаар шүүгдэх.

Ов мэхтэнг тэр шийтгэнэ, **Сур. үгс 12:2**. Бид дэлхийтэй хамт шийтгэгдэхгүйн тулд Их Эзэнээр зэмлэгддэг, **1 Кор. 11:32**. Бидний үг, ажил мөн бодлууд биднийг буруутгах

болно, **Алма** 12:14. Эдгээр зүйлийг мэдээд мөн тэдгээрийг хийхгүй байснаар хүн буруушаагдана, **Хил** 14:19. Хэрэв бид хөдөлмөрлөхөө боливол, бид буруушаалтын дор авчрагдах болно, **Моро** 9:6. Ахыгаа уучилдаггүй тэрээр буруушаагдахаар Их Эзэний өмнө зогууно, **С ба Г** 64:9. Агуу гэрлийн эсрэг нүгэл үйлддэг тэрээр илүү агуу зэмлэлийг хүлээж авах болно, **С ба Г** 82:3. Наманчилж мөн Мормоны Номыг дурсан санах хүртэл бүх Сүм зэмлэл дор байна, **С ба Г** 84:54–57.

БУРХАН, БУРХАН ТЭРГҮҮТЭН.

Ариун Сүнс; Есүс Христ; Их Эзэн; Тэнгэр дэх Эцэгийг мөн үз

Бурхан Тэргүүтэнд тусдаа гурван хүн: Мөнхийн Эцэг Бурхан; түүний Хүү Есүс Христ; мөн Ариун Сүнс байдаг. Бид эд бүгдэд итгэдэг (ИТ 1:1). Эцэг Хүү хоёр бодит махан бие хийгээд ястай, харин Ариун Сүнс бол махан бие болон ясгүй сүнсэн хүн болохыг бид хожмын үеийн илчлэлтээ мэддэг билээ (С ба Г 130:22–23). Энэ гурван хүн төгс нэгдэл, түүнчлэн зорилгын эв нийц хийгээд сургаалын хувьд нэг юм (Иохан 17:21–23; 2 Ниф. 31:21; 3 Ниф. 11:27, 36).

Бурхан Эцэг: Энэ бол Бурханы нэр болох Эцэг буюу Элохим хэмээх нийтлэг утгатай. Тэрээр бидний сүнснүүдийн эцэг учраас Эцэг хэмээн нэрлэгддэг (Малах. 2:10; Тоол. 16:22; 27:16; Мат. 6:9; Еф. 4:6; Евр. 12:9). Бурхан Эцэг бол ертөнцийн дээд захирагч мөн. Тэрээр бүхнийг чаддаг (Эхл. 18:14; Алма 26:35; С ба Г 19:1–3), бүхнийг мэддэг (Мат. 6:8; 2 Ниф. 2:24), мөн Сүнсээрээ дамжуулан газар бүхэнд байдаг билээ (Дуул. 139:7–12; С ба Г 88:7–13, 41). Хүн төрөлхтөн Бурхантай онцгой харилцаатай байдаг нь бусад бүх бүтээгдсэн зүйлүүдээс хүнийг ангид болгодог: эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд Бурханы сүнсэн хүүхдүүд мөн (Дуул. 82:6; 1 Иохан 3:1–3; С ба Г 20:17–18).

Бурхан Эцэг хүн дээр хүрч ирсэн буюу түүнтэй ярьсан хэдхэн тохиолдол тэмдэглэгджээ. Тэрээр Адам Ева хоёртой ярилцсаныг судрууд өгүүлдэг (Моце 4:14–31) бөгөөд Есүс Христийг нилээд хэдэн тохиолдолд танилцуулжээ (Мат. 3:17; 17:5; Иохан 12:28–29; 3 Ниф. 11:3–7). Тэрээр Стефен (Үйлс 7:55–56) болон Иосеф Смит (ИС—Т 1:17) дээр хүрч ирсэн билээ. Үүний дараа тэрээр Иосеф Смит Сидней Ригдон хоёр дээр хүрч иржээ (С ба Г 76:20, 23). Бурханыг хайрладаг хийгээд зүрх сэтгэлээ түүний өмнө цэвэршүүлдэг хүмүүст Бурхан заримдаа тэрбээр Бурхан мөн гэдгийг харуулж мөн тэд мэдэж авах онцгой боломжийг соёрхдог бөгөө (Мат. 5:8; 3 Ниф. 12:8; С ба Г 76:116–118; 93:1).

Миний Бурхан, миний Бурхан, юунд Та намайг орхив? **Марк** 15:34. Эдгээр хүмүүс бол Хамгийн Дээд Бурханы зарц нар билээ, **Үйлс** 16:17. Бид Түүний үр удам, **Үйлс** 17:28–29. Чи өөрийнхөө ариун ёслолуудыг Бүхний Дээдэд зориулах ёстой, **С ба Г** 59:10–12. Бурханы бүтээсэн сүнснүүдийг Енох болгоов, **Моце** 6:36. Цэвэр Ариун Хүн нь түүний нэр бөгөө, **Моце** 6:57.

Бурхан Хүү: Иехова хэмээн нэрлэгддэг Бурхан нь Хүү буюу Есүс Христ юм (Иса. 12:2; 43:11; 49:26; 1 Кор. 10:1–4; 1 Тим. 1:1; Илч 1:8; 2 Ниф. 22:2). Есүс Эцэгийн удирдлага дор, мөн түүнтэй төгс эв нийцэлд ажилладаг. Бүх хүмүүн төрөлхтөн түүний ах, эгч дүүс юм, учир нь тэрбээр Елохимын сүнсэн хүүхдүүдийн ууган нь билээ. Судрын зарим ишлэлүүд түүнийг *Бурхан* гэсэн үгээр нэрлэсэн байдаг. Жишээ нь, сударт Бурхан тэнгэр газрыг бүтээв (Эхл. 1:1) гэсэн байдаг хэдий ч, энэ нь үнэндээ Бурхан Эцэгийн удирдлага дор ажилласан Бүтээгч Есүс байсан билээ (Иохан 1:1–3, 10, 14; Евр. 1:1–2).

Эзэн өөрийгөө **БИ БАЙДАГ** гэв, **Ег.** 3:13–16. Би бол Эзэн (Иехова) бөгөөд

надаас өөр аврагч байхгүй, **Иса.** 43:11 (Иса. 45:23). Би бол дэлхийн гэрэл, **Иохан** 8:12. Абрахамыг бий болохоос өмнө, би байдаг, **Иохан** 8:58. Их Эзэн хүмүүний дунд шавар асарт тохинуулах болно, **Моз.** 3:5–10. Христ хэрхэн Эцэг болон Хүү байдгийг Абинадай тайлбарлав, **Моз.** 15:1–4 (Ифер 3:14). Их Эзэн Жаредын ахад харагдав, **Ифер** 3. Өөрийн Их Эзэн, өөрийн Бурхан Христийн үгсийг сонс, **Моро.** 8:8. Иехова бол амьд хийгээд нас барсны аль алиных нь шүүгч мөн, **Моро.** 10:34. Иосеф Смит, Сидней Ригдон хоёр дээр Есүс хүрч ирэв, **С ба Г** 76:20, 23. Их Эзэн Иехова Көртландын ариун сүмд хүрч ирэв, **С ба Г** 110:1–4. Иехова Абрахамтай ярив, **Абр.** 1:16–19. Есүс Иосеф Смит дээр хүрч ирэв, **ИС—Г** 1:17.

Бурхан Ариун Сүнс: Ариун Сүнс бол мөн Бурхан бөгөөд Ариун Сүнс, Сүнс, Бурханы Сүнс хэмээн бусад адил төстэй нэрээр дуудагддаг. Хүн Ариун Сүнсний тусламжтайгаар Бурханы тааллыг, түүнчлэн Есүс бол Христ (Аврагч) гэдгийг мэдэж болно (1 Кор. 12:3).

Юу хэлэх ёстойг чинь Ариун Сүнс та нарт зааж өгнө, **Лук** 12:12. Ариун Сүнс бол Туслагч мөн, **Иохан** 14:26 (Иохан 16:7–15). Есүс Ариун Сүнсээр дамжуулан Төлөөлөгчдөд зарлигууд өгөв, **Үйлс** 1:2. Бурхан болон Христийн тухай Ариун Сүнс гэрчилдэг, **Үйлс** 5:29–32 (1 Кор. 12:3). Ариун Сүнс тэрчлэн бидэнд гэрч болдог, **Евр.** 10:10–17. Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлсийн тухай үнэнийг мэдэж болно, **Моро.** 10:5. Ариун Сүнс бол илчлэлтийн сүнс мөн, **С ба Г** 8:2–3 (С ба Г 68:4).

БУРХАНЛИГ БУС. Бузар; бузар явдал; Ёс бус, Ёс бус явдал; Нүгэл; Шударга бус, Шударга бус явдлыг *мөн үз*

Бурханы таалал хийгээд зарлигуудтай нийцэхгүй хүн буюу ямар нэг зүйл; ёс бус хийгээд ариун бус явдал.

Хорон муу хүний зам сөнөх болно, **Дуул.** 1:6. Хэрэв зөвт хүн арай гэж аврагдах юм бол, бурхангүй хүн яах болж байна, **1 Петр** 4:18. Бурханлиг бусаас өөрсдөө татгалзагтун, **Моро.** 10:32. Бурханлиг бус хүнд өс хонзон хурдан ирэх болно, **С ба Г** 97:22. Бурханлиг бусчуудын дунд Аврагчийн дуу хоолой чангаар ярьсан нь үгүй, **С ба Г** 138:20.

БУРХАНЛИГ ЧАНАР, БУРХАН.

Бурхан, Бурхан Тэргүүтнийг үз

БУРХАНЛИГ НӨЛӨӨ, БУРХАНЛИГААР НӨЛӨӨЛӨХ.

Ариун Сүнс; Илчлэлтийг *мөн үз*

Бурханаар хүнд өгөгддөг бурханлиг удирдамж буюу нөлөөлөл. Бурханлигаар нөлөөлөгдөх нь хүний оюун буюу зүрх сэтгэлд янз бүрийн арга замаар, Сүнсээр олонтаа ирдэг.

Гал гарсны дараа намуун хүнгэнэх дуу гарлаа, **Хаад.** дээд 19:12. Ариун Сүнс та нарт бүх зүйлийг заах бөгөөд та нарт бүх зүйлийг сануулах болно, **Иохан** 14:26. Үнэний Сүнс та нарыг бүх үнэн уруу удирдах болно, **Иохан** 16:13. Хийвэл зөжих зүйлүүдийг би урьдаас мэдэхгүй байсан учир бибээр Сүнсэнд хөтлөгдсөн байлаа, **1 Ниф.** 4:6. Их Эзэний дуу хоолой миний оюунд ирэв, **Инос** 1:10. Сайныг үйлдэхэд урьж мөн үүнд татдаг юм болгон нь Бурханаас урамшуулагддаг, **Моро.** 7:13–16. Би та нарын оюунд амар амгаланг яриагүй гэж үү? **С ба Г** 6:23. Оюун хийгээд зүрх сэтгэлд тань би та нарт ярих болно, **С ба Г** 8:2. Боггалийг чинь баяр хөөрөөр дүүргэх оюуныг тань миний Сүнс гэгээрүүлэх болно, **С ба Г** 11:13. Ярих мөн бичих тэр зүйл чинь яг тэр мөчид чамд өгөгдөх болно, **С ба Г** 24:6 (С ба Г 84:85). Намуухан, аниргүй дуу хоолой бүх зүйлийг нэвт, цоо хатган шивнэдэг, **С ба Г** 85:6.

БУРХАНЫ ЗАРЛИГУУД. Арван Зарлиг; Бурханы үг;

Дуулгавартай, Дуулгавартай
байдал, Дуулгавартай дагах;
Хуулийг мөн үз

Хүн төрөлхтөнд Бурханы ганцаарчлан буюу нийтэд нь өгсөн хуулиуд болон шаардлагууд. Зарлигуудыг сахих нь дуулгавартнуудад Их Эзэний адислалуудыг авчрах болно (С ба Г 130:21).

Ноа Бурхан түүнд зарлигласны дагуу бүхнийг хийжээ, **Эхл.** 6:22. Миний тогтоолууд дотор алхаж, миний зарлигуудыг сахь, **Лев.** 26:3. Миний зарлигуудыг сахь, мөн амьдар, **Сур. үгс** 4:4 (Сур. үгс 7:2). Хэрэв та нар надад хайртай бол зарлигуудыг минь сахь, **Иохан** 14:15 (С ба Г 42:29). Гуйсан болгоноо Түүнээс бид хүлээн авдаг, учир нь бид түүний зарлигуудыг сахьдаг, **1 Иохан** 3:22. Түүний зарлигууд хүнд дарамт биш билээ, **1 Иохан** 5:3. Зарлигуудыг хөдөлшгүйгээр сахь, **1 Ниф.** 2:10. Зарлигийг гүйцэлдүүлэх замыг бэлтгэлгүйгээр Их Эзэн зарлиг өгдөггүй, **1 Ниф.** 3:7 Би Бурханы чанд зарлигуудын дагуу үйлдэх ёстой, **Иаков** 2:10. Миний зарлигуудыг дагахын хэрээр та нар уг нутагт дэгжих болно, **Жером** 1:9 (Алма 9:13; 50:20). Өөрийн залууд Бурханы зарлигуудыг дагаж сур, **Алма** 37:35. Эдгээр зарлигууд нь надаас юм, **С ба Г** 1:24. Эдгээр зарлигуудыг судлагтун, **С ба Г** 1:37. Миний зарлигуудыг сахьдаггүй тэд аврагдаж чадахгүй, **С ба Г** 18:46 (С ба Г 25:15; 56:2). Миний зарлигууд сүнслэг; тэд ердийн болон түр зуурын бус, **С ба Г** 29:35. Бид Их Эзэний тааллыг ойлгож болохын тулд Зарлигууд өгөгддөг. **С ба Г** 82:8. Их Эзэн надад зарлигласнаас өөрийг би мэдэх нь үгүй, **Мосе** 5:6. Их Эзэн тэдэнд өөрийнх нь зарлигласан бүхнийг хийх нь үү гэдгээр хүмүүнд нотлох болно, **Абр.** 3:25.

БУРХАНЫ МӨН ЧАНАР. Мөнх амьдрал; Өргөмжлөл; Хүн, Хүмүүс — Хүмүүн; Тэнгэрлэг Эцэгтэй адилхан болох боломжийг мөн үз

БУРХАНЫ НУУЦУУД

Бурханы нууцууд бол зөвхөн илчлэлтээр мэдэгддэг сүнсийн үнэнүүд юм. Бурхан өөрийн нууцуудыг сайн мэдээнд дуулгавартай тэдэнд илчилдэг. Бурханы зарим нууцууд хараахан илчлэгдээгүй байна.

Тэнгэрийн хаанчлалын нууцуудыг мэдэх нь та нарт өгөгдсөн юм, **Мат.** 13:11. Би бүх нууцуудыг ойлгодог байлаа ч, надад хайр байхгүй бол би юу ч биш, **1 Кор.** 13:2. Бурханы нууцуудын агуу их мэдлэг Нифайд байлаа, **1 Ниф.** 1:1. Бурханы нууцуудыг мэдэх нь олонд нь өгөгдсөн юм, **Алма** 12:9. Иймүүдэд нь Бурханы нууцуудыг мэдэх нь өгөгдсөн байдаг, **Алма** 26:22. Эдгээр нууцууд надад хараахан бүрэн дүүрэн мэдүүлэгдээгүй, **Алма** 37:11. Бурханаас өөрөөс нь бусад хэн ч үл мэдэх олон нууц байдаг, **Алма** 40:3. Бурханлиг чанарын нууц хичнээн агуу билээ, **С ба Г** 19:10. Хэрэв та нар асуух аваас, та нар илчлэлт хүлээн авч мөн хаант улсуудын нууцуудыг мэдэх болно, **С ба Г** 42:61, 65 (1 Кор. 2:7, 11–14). Зарлигуудыг сахьдаг түүнд хаант улсын нууцууд өгөгдөх болно, **С ба Г** 63:23. Бибээр тэдэнд бүх нууцыг илчлэх болно, **С ба Г** 76:7. Дээд санваар нь нууцуудын түлхүүрийг атгадаг, **С ба Г** 84:19. Их Эзэн өөрийн ирэлтээр хүмүүний үл мэдэх нуугдмал зүйлүүдийг илчлэх болно, **С ба Г** 101:32–33. Мелкизедек Санваар нь хаант улсуудын нууцуудыг хүлээн авах онцгой боломжтой билээ, **С ба Г** 107:19.

БУРХАНЫ ОХИД ХӨВГҮҮД.

Бурханаас төрөх; Дахин төрөх, Төрсөн; Христийн хүүхдүүд; Хүн, Хүмүүс; Цагаатгал, Цагаатгахыг мөн үз

Судрууд эдгээр нэр томъёонуудыг хоёр замаар хэрэглэдэг. Нэг талаар, бид бүгдээрээ яах аргагүй Тэнгэрлэг Эцэгийнхээ сүнсэн хүүхдүүд. Нөгөө талаар, Бурханы охид хөвгүүд бол

Христийн цагаатгалаар дамжин дахин төрсөн хүмүүс юм.

Эцэгийн Сүнсэн хүүхдүүд: Та нар бол бурхад, хамгийн дээдийн хүүхдүүд, **Дуул.** 82:6. Бид бол Бурханы үр удам, **Үйлс** 17:29. Сүнснүүдийн Эцэгт захирагддаг байх, **Евр.** 12:9. Би Бурханы хүү, **Моце** 1:13.

Цагаатгалаар дамжин дахин төрсөн хүүхдүүд: Өөрийг нь хүлээн авсан болгонд, Бурханы хүүхэд болох эрхийг тэр өгөв, **Иохан** 1:12 (Ром 8:14; 3 Ниф. 9:17; С ба Г 11:30). Одоо бид Бурханы хүүхдүүд боллоо, **1 Иохан** 3:1–2. Та нар Христийн хүүхдүүд, түүний хөвгүүд охид хэмээн нэрлэгдэх болно, **Моз.** 5:7. Бүх хүмүүс түүний хөвгүүд, охид болж дахин төрөх ёстой, **Моз.** 27:25. Тэд миний хөвгүүд охид болох болно, **Ифер** 3:14. Та нар гарцаагүй Христийн хүүхэд байх болно, **Моро.** 7:19. миний сайн мэдээг хүлээн авах тэд бүгд хөвгүүд охид болой, **С ба Г** 25:1. Тэд бол бурхад, бүр Бурханы хөвгүүд болой, **С ба Г** 76:58. Тийнхүү бүгд миний хөвгүүд болох ажгуу, **Моце** 6:68. Олон нь итгэж мөн Бурханы хөвгүүд болох бөлгөө, **Моце** 7:1.

БУРХАНЫ ҮГ. Бурханы зарлигууд;
Илчлэлт; Судруудыг мөн үз

Бурханы заавар, зарлигууд буюу захиас. Бурханы хүүхдүүд түүний үгийг Сүнсээр дамжуулан илчлэлтээр шууд буюу түүний сонгосон үйлчлэгчдээс хүлээн авч болдог (С ба Г 1:38).

Хүн ЭЗЭНий амнаас гарах үг бүхнээр амьдардаг, **Дэд хууль** 8:3 (Мат. 4:4; С ба Г 84:43–44). Таны үг бол миний хөл дэх дэнлүү, миний зам дахь гэрэл юм, **Дуул.** 119:105. Тэд Ариун Сүнсээр дүүрч Бурханы үгийг зоригтойгоор ярьжээ, **Үйлс** 4:31–33. Төмөр саваа бол амьдралын мод уруу хөтөлдөг Бурханы үг байв, **1 Ниф.** 11:25 (1 Ниф. 15:23–25). Та нар мэдрэхээс өнгөрсөн, иймээс та нар түүний үгсийг мэдэрч чадсангүй, **1 Ниф.** 17:45–46. Бурханы үгийг эсэргүүцэх

түүнд халаг, **2 Ниф.** 31:20 (2 Ниф. 32:3). Итгэлгүйнхээ улмаас тэд Бурханы үгийг ойлгож чадсангүй, **Моз.** 26:3 (Алма 12:10). Бурханы үгийг мэдэхийн тулд тэд судруудыг хичээнгүйлэн судалсан байв, **Алма** 17:2. Бурханы үгийн нөлөөлөх хүчийг сорь, **Алма** 31:5. Алма Бурханы үгийг үртэй зүйрлэжээ, **Алма** 32:28–43. Ариун Сүнсээр хөдөлгөгдөн тэд ямар ч зүйлийг ярьсан тэр нь Их Эзэний үг байх болно, **С ба Г** 68:4. Бурханы амнаас гарах үг бүрээр амьдар, **С ба Г** 84:44–45. Миний үгийг нөөцлөх хэн боловч хууртагдах нь үгүй, **ИС—Мат.** 1:37.

БУРХАНЫ ХААНТ УЛС БУЮУ ТЭНГЭРИЙН ХААНТ УЛС.

Есүс Христийн Сүм; Селестиел алдар сууг мөн үз

Дэлхий дээрх Бурханы хаант улс бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм юм (С ба Г 65). Сүмийн зорилго нь гишүүдийгээ селестиел хаант улс буюу тэнгэрийн хаант улсад үүрд мөнх амьдрахад нь бэлтгэх явдал мөн. Гэсэн ч судрууд Сүмийг заримдаа тэнгэрийн хаант улс хэмээн нэрлэдэг нь Сүм бол дэлхий дээрх тэнгэрийн хаант улс мөн гэсэн утгатай юм.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол дэлхий дээрх Бурханы хаант улс боловч, эдүгээ энэ нь шашны хаант улсаар хязгаарлагдаж байгаа болно. Мянганы үед Бурханы хаант улс нь улс төр хийгээд шашных аль аль нь байх болно.

ЭЗЭН би үүрд мөнхөд Хаан юм, **Дуул.** 10:16 (Дуул. 11:4). Тэнгэрийн Бурхан хэзээ ч устгагдашгүй нэг хаант улсыг байгуулах болно, **Дан.** 2:44 (С ба Г 138:44). Наманчлагтун та нар, учир нь тэнгэрийн хаант улс ойрхон байна, **Мат.** 3:2 (Мат. 4:17). Таны хаанчлал ирэх болтугай, хүсэл тань газар дээр биелэгдэх болтугай, **Мат.** 6:10. Та нар эхлээд Бурханы хаант улсыг эрэлхийлэгчтүн, **Мат.** 6:33 (3 Ниф. 13:33). Би

чамд хаант улсын түлхүүрүүдийг өгөх болно, **Мат.** 16:19. Ирэгтүн, та нарын тул бэлтгэгдсэн хаант улсыг өвлөгтүн, **Мат.** 25:34. Миний Эцэгийн хаант улсад та нартай хамт би ариун ёслолоос хүртэхэд, **Мат.** 26:26–29. Та нар бүх бошиглогчдыг Бурханы хаант улсад харах болно, **Лук** 13:28. Зөвт бус хүмүүс Бурханы хаант улсыг өвлөхгүй, **1 Кор.** 6:9. Махан бие ба цус Бурханы хаант улсыг өвлөж чадахгүй, **1 Кор.** 15:50. Та нар баялгуудыг эрэлхийлэхээсээ өмнө Бурханы хаант улсыг эрэлхийл, **Иаков** 2:18. Ариун бус зүйл тэнгэрийн хаант улсыг өвлөж чадахгүй, **Алма** 11:37. Чи миний Эцэгийн хаант улсад тэдэнтэй хамт амарч болох бөлгөө, **С ба Г** 15:6. Хаант улс буюу Сүмийн түлхүүрүүд та нарт өгөгдсөн билээ, **С ба Г** 42:69 (С ба Г 65:2). Тэнгэрийн хаант улс ирж болохын тулд Бурханы хаант улс урагш одох болно, **С ба Г** 65:5–6. Энэ хаант улсын түлхүүрүүд чамаас хэзээ ч авагдахгүй, **С ба Г** 90:3. Бяцхан хүүхэд адил та нарыг хүлээн авах хэн боловч миний хаант улсыг хүлээн авах болно, **С ба Г** 99:3. Миний Сүм, бүр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм ийнхүү нэрлэгдэх болно, **С ба Г** 115:4. Тэнгэр нээгдэж мөн бибээр Бурханы селестиел хаант улсыг болгоов, **С ба Г** 137:1–4.

БУРХАНЫ ХУРГА. Дээгүүр өнгөрсний баяр; Есүс Христ; Цагаатгал, Цагаатгахыг *мөн үз*

Бидний өмнөөс золиослол хийсэн Есүсийг нэрлэсэн Аврагчийн нэг нэр. Алагдах хурга адилаар тэр авчрагдав, **Иса.** 53:7 (Моз. 14:7). Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харагтун, **Иохан** 1:29 (Алма 7:14). Толбогүй хурга лугаа адил Христийн үнэт цусаар та нар гэтэлгэгдсэн билээ, **1 Петр** 1:18–20. Нядлуулсан хурга зохистой, **Илч.** 5:12. Бид Хурганы цусаар Сатаны ялан дийлсэн, **Илч.** 12:11. Тэд түүнд итгэлтэйн учир эдгээр нь Хурганы цусанд цагаан болгогджээ, **1 Ниф.** 12:11.

Бурханы Хурга бол Мөнхийн Эцэгийн Хүү, түүнчлэн дэлхийн аврагч мөн, **1 Ниф.** 13:40 (1 Ниф. 11:21). Та нар Хурганы цусаар цэвэрлэгдэж болох магадын тул Есүс Христийн нэрээр Эцэгт хандан хүчтэйгээр залбиран гуй, **Морм.** 9:6 (Илч. 7:14; Алма 34:36). Хүний Хүү бол дэлхийн сууринаас алагдсан Хурга мөн, **Моце** 7:47.

БУРХАНЫ ХҮҮ. Бурхан, Бурхан Тэргүүтэн; Есүс Христийг *үз*

БУРХАНЫ ХҮҮХДҮҮД. Бурханы хөвгүүд охид; Хүн, Хүмүүсийг *үз*

БУУЛГА. Шавийг *мөн үз*

Мал буюу хүний хүзүүнд угладаг, хөллөж холбодог тоног. Христийн буулга нь шавь байхын бэлэгдэл байхад, боолчлолын буулга нь дарлалын бэлэгдэл юм.

Миний буулга амархан, мөн миний ачаа хөнгөн, **Мат.** 11:29–30. Ул итгэгчдийн хамт нэг буулганд бүү орогтун, **2 Кор.** 6:14. Боолчлолын буулганд бүү орогтун, **Галат** 5:1. Бид хэнийг ч боолчлолын буулганд оруулахыг хүсэхгүй байна, **Алма** 44:2. Гэгээнтнүүдийн зовлон бол төмөр буулга, хүчтэй тууз, тамын гинж юм, **С ба Г** 123:1–3, 7–8.

БҮДҮҮЛЭГ ҮГ ХЭЛЛЭГ.

Доромжлол, Доромжлохыг *мөн үз*

Ариун нандин зүйлүүдийг, ялангуяа Бурханы нэрийг хүндэтгэл бишрэлгүйгээр, үл хүндэтгэсэн буюу жигшүүртэй байдлаар ярих.

Чи өөрийн Бурхан ЭЗЭНий нэрийг дэмий бүү дурд, **Ег.** 20:7 (2 Ниф. 26:32; Моз. 13:15; С ба Г 136:21). Бид яагаад өвөг дээдсийнхээ гэрээг бузарлана вэ? **Малах.** 2:10. Бодлогогүй хэлсэн үг бүрийнхээ төлөө хүмүүс шүүлтийн өдөр тайлагнах болно, **Мат.** 12:34–37. Магтаал, хараал нэг л амнаас гардаг аж, ийм байж болохгүй, **Иаков** 3:10. Үгс маань бид-

нийг буруутгах болно, **Алма** 12:14 (Моз. 4:30). Миний нэрийг уруулдаа хэрхэн авах тухайд бүх хүмүүн болгоомжтой байг, **С ба Г** 63:61–62.

БҮТЭЭГЧ. Бүтээл, Бүтээх; Есүс Христийг үз

БҮТЭЭЛ, БҮТЭЭХ. Дэлхий; Есүс Христ; Сүнсний бүтээл; Хүндэтгэлийн өдөр; Эхлэлийг мөн үз

Эмхлэн зохион байгуулах. Бурхан, өөрийн Хүү Есүс Христээр дамжуулан ажиллаж, дэлхийг бий болгохын тулд байгаль дахь бичил биетүүдийг эмхлэн зохион байгуулжээ. Тэнгэрлэг Эцэг Есүс Христ хоёр өөрсдийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээсэн билээ (Мосе 2:26–27).

Эхэнд Бурхан тэнгэр газрыг бүтээжээ **Эхл.** 1:1. Хүнийг өөрсдийнхөө дүр төрхөөр бүтээгчээ, **Эхл.** 1:26 (Мосе 2:26–27; Абр. 4:26). Бүх юм түүгээр бий болсон, **Иохан** 1:3, 10. Тэнгэр дэх бүх юмс түүгээр бүтээгдсэн билээ, **Кол.** 1:16 (Моз. 3:8; Хил. 14:12). Бурхан хүүгээрээ дамжуулан дэлхийнүүдийг бүтээв, **Евр.** 1:2. Эхлэлд хүн бүтээгдсэн байв, **Моз.** 7:27. Бибээр тэнгэр ба газар мөн бүх зүйлсийг бүтээсэн билээ, **3 Ниф.** 9:15 (Морм. 9:11, 17). Эхлэлд бүх хүн миний өөрийн төрхөөр бүтээгдсэн, **Ифер** 3:15. Есүс Христ тэнгэр мөн газрыг бүтээжээ, **С ба Г** 14:9. Тэрбээр хүмүүнийг, эрэгтэй, эмэгтэйдгээр нь өөрийнхөө дүр төрхөөр, өөртэйгөө адилаар бүтээжээ, **С ба Г** 20:18. Тоо томшгүй олон дэлхийг бүтээсэн буюу би, **Мосе** 1:33. Өөрийн Төрсөн Ганцаар тэнгэрийг бүтээлгэсэн бөлгөө, **Мосе** 2:1. Их Эзэн Бурхан бибээр, бүх зүйлийг дэлхийн гадаргуу дээр жам ёсоороо байхаас нь өмнө сүнслэг хэлбэрээр бүтээсэн юм, **Мосе** 3:5. Үүнтэй адил сая сая дэлхийнүүд байдаг бол таны бүтээлтийн тоонд эхлэл гэж үгүй бөлгөө, **Мосе** 7:30. Бурхад тэнгэрийг зохион байгуулж бий болгосон юм, **Абр.** 4:1.

БҮХ ГАЗАРТ ҮЗЭГДЭГЧ. Бурхан, Бурхан Тэргүүтнийг мөн үз

Сүнсээр дамжуулан газар болгонд байх Бурханы чадвар (Дуул. 139:7–12; С ба Г 88:7–13, 41).

БҮХНИЙГ МЭДЭГЧ. Бурхан, Бурхан Тэргүүтнийг мөн үз

Бүх мэдлэгтэй байх бурханлиг шинж чанар (Мат. 6:8; 2 Ниф. 2:24).

БҮХНИЙГ ЧАДАГЧ. Бурхан, Бурхан Тэргүүтнийг мөн үз

Бүх хүч чадалтай байх бурханлиг шинж чанар (Эхл. 18:14; Алма 26:35; С ба Г 19:1–3).

БЭЛГИЙН ХАРИЛЦААНЫ ЁС СУРТАХУУНГУЙ ЯВДАЛ.

Завхайрал; Садар самуун; Тачаангуй, Тачаадалтыг мөн үз

Садар самуун, завхайрал, ижил хүйстэнтэйгээ бэлгийн харьцаанд орох, лесби, цус ойртолт болон бусад аливаа бэлгийн харилцааны ариун бус зүйлд санаатайгаар оролцох.

Бид аавдаа архи уулгаад бид түүнтэй унтацгаая, **Эхл.** 19:30–36. Реубен явж, мөн аавынхаа татвар эм Билхатай унтав, **Эхл.** 35:22 (Эхл. 49:4; Шаст. дээд 5:1). Хоёр эр хүйстэн унтах буюу бэлгийн бусад гажуу зүйлс нь жигшүүрт юм, **Левит** 18:22–23. Хэрэв эрэгтэй хүн эмэгтэй хүнийг өөртэйгөө унтуулахаар хүчлэх аваас, зөвхөн эрэгтэй л гэм нүгэлтэй, **Дэд хууль** 22:25–27. Эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр завхайрсан хэрэг, **Мат.** 5:28 (3 Ниф. 12:28). Садар самуун, бузар байдал, муу хүсэл нь завхайрал юм, **Кол.** 3:5. Хожмын өдрүүдэд хүн тачаангуй хүсэлтэй болно, **2 Тим.** 3:1–3. Бэлгийн нүгэл нь жигшүүрт юм, **Алма** 39:3–5.

БЭЛЭВСЭН ЭМЭГТЭЙ.

Халамжийг мөн үз

Нөхөр нь нас бараад, дахин гэрлээгүй байгаа эмэгтэй.

Эцэггүй хийгээд бэлэвсэн хүмүүсийг ирүүлж хооллох болно, **Дэд хууль** 14:29. Энэ ядуу бэлэвсэн эмэгтэй өөртөө байгаа бүхнээ өглөө, **Марк** 12:41–44. Эцэггүй хүмүүс, бэлэвсэн эмэгтэйчүүдийг зүдрэх цагт нь эргэн тойрч бай, **Иаков** 1:27. Бэлэвсэн хүнийг дарлагчдын эсрэг Их Эзэн шуурхай гэрч байх болно, **3 Ниф.** 24:5 (Зех. 7:10). Бэлэвсэн болон өнчин хүмүүс хангагдах болно, **С ба Г** 83:6 (С ба Г 136:8).

БЭЛЭГ. Ариун Сүнсний бэлэг;
Сүнсний бэлгүүдийг *мөн үз*

Бурхан олон адислал хийгээд бэлгүүдийг хүнд өгдөг.

Сүнсний олон бэлгүүд бий, **1 Кор.** 12:4–10. Үлэмж агуу бэлгүүдийг хүсэн эрэлхийлэгтүн, **1 Кор.** 12:31. Төгс бэлэг бүхэн Бурханаас ирдэг, **Иаков** 1:17. Ариун Сүнсний хүч бол Бурханы бэлэг мөн, **1 Ниф.** 10:17. Бэлгүүд байхгүй хэмээн хэлдэг тэд Христийн сайн мэдээг мэддэггүй, **Морм.** 9:7–8. Сайн бэлэг бүхэн Христээс ирдэг, **Моро.** 10:8–18. Мөнх амьдрал бол Бурханы бүх бэлгээс хамгийн агуу нь билээ, **С ба Г** 14:7 (1 Ниф. 15:36). Их Эзэнийг хайрладаг хүмүүст бэлгүүд өгөгддөг, **С ба Г** 46:8–11. Бүх хүмүүс өөрсдөд нь өгөгдсөн бэлэг болгонтой байдаггүй, **С ба Г** 46:11–29.

БЭЛЭГ ДЭЛ

Ямар нэг зүйлийг өөр зүйлийн дүр төрхөөр буюу адилтган ашиглах. Судруудад бэлэгдэл нь сайн мэдээний зарчим буюу сургаалыг төлөөлүүлэхийн тулд адил төстэй юм, үйл явдал буюу нөхцөл байдлыг ашигладаг. Жишээ нь, Мормоны Номны бошиглогч Алма үрийг Бурханы үгийг төлөөлүүлэхэд ашигласан байдаг (Алма 32).

Олон сударт бошиглогчид Есүс Христийн тухай заахдаа бэлэгдлийг ашигладаг байв. Эдгээр бэлэгдлийн заримд нь ёс жаяг мөн ёслолууд (Моисе 6:63), золиослолууд (Евр. 9:11–

15; Моисе 5:7–8), ариун ёслол (Лук 22:13–20; ИСО, Марк 14:20–24) болон баптисм (Ром 6:1–6; С ба Г 128:12–13) багтана. Библийн олон нэр бэлэгдлийн юм. Хуучин Гэрээний асрын ёслол хийгээд Мосегийн хууль мөнхийн үнэнийг төлөөлдөг (Евр. 8–10; Моз. 13:29–32; Алма 25:15; Хил. 8:14–15). Бусад жишээнүүдийг Мат. 5:13–16; Иохан 3:14–15; Иаков 4:5; Алма 37:38–45-аас үз.

БЭРХШЭЭЛ. Зэмлэл, Зэмлэх;
Мөрдлөг хавчлага, Мөрдөн хавчих; Тэвчих; Уруу таталт, Уруу татахыг *мөн үз*

Хүнд сорилт, гай зовлон хийгээд уй гашуу зэрэг бэрхшээлээр дамжин хүмүүн Их Эзэн уруу эргэснээр сүнслэг өсөлт болон мөнхийн дэвшил өөд хөтөлдөг олон туршлагатай болж чадна.

Бурхан өөрөө бүхий л гай гамшиг зовлонгоос чинь та нарыг аварсан билээ, **1 Сам.** 10:19. Тэд зовлонгийнхоо дунд Эзэнд хашгирсан, **Дуул.** 107:6, 13, 19, 28. Хэдийгээр Эзэн та нарт эмгэнэлийн талхыг өгсөн боловч, та нарын багш нар хөдөлгөдөггүй, **Иса.** 30:20–21. Бүх зүйлд сөрөг тал байх ёстой нь шаардлагатай, **2 Ниф.** 2:11. Хэрэв гашуун нь тэдэнд байхгүй аваас тэд чинхэрлэгийг мэдэж чадах нь үгүй, **С ба Г** 29:39. Чиний бэрхшээлүүд хэсэг хугацаанд байх болно, **С ба Г** 121:7–8. Эдгээр бүх зүйл чамд туршлага суулгах болно, мөн чиний сайн сайхны тулд байх болно, **С ба Г** 122:5–8. Тэд сайн сайхны үнэ цэнийг мэдэж болохын тулд, мөн тэд гашууныг амсах ажгуу, **Моисе** 6:55.

БЯСАЛГАХ. Тунгаан бодохыг
мөн үз

ВИЛЛЯМС, ФРЕДЕРИК Г.

Дээд Санваартны Ерөнхийлөгчийн Зөвлөлд зөвлөхөөр хэсэг хугацаанд үйлчилж байсан, сэргээгдсэн Сүмийн анхны нэг удирдагч (С ба Г 81; 90:6, 19; 102:3).

ВИТМЕР, ДАВИД

Сэргээгдсэн Сүмийн анхны нэг удирдагч, Мормоны Номны бурханлиг гарал үүсэл хийгээд үнэнийг гэрчилсэн Гурван гэрчийн нэг (С ба Г 14, 17–18). Сургаал ба Гэрээний 14 болон 30:1–4-т Их Эзэн түүнд ганцаарчлан заавар өгчээ.

ВИТМЕР, ЖОН

Сэргээгдсэн Сүмийн анхны нэг удирдагч бөгөөд Мормоны Номны Найман гэрчийн нэг. Мормоны Номны оршил хуудсууд дахь “Найман гэрчийн гэрчлэлийг” үз. Тэрчлэн тэрээр сайн мэдээг номлохоор дуудагдсан ажээ (С ба Г 30:9–11).

ВИТМЕР, ПЕТР БАГА

Сэргээгдсэн Сүмийн анхны нэг удирдагч бөгөөд Мормоны Номны Найман гэрчийн нэг. Мормоны Номны оршил хуудсууд дахь “Найман гэрчийн гэрчлэлийг” үз. Сургаал ба Гэрээний 16 болон 30:5–8-д Их Эзэн түүнд ганцаарчлан заавар өгчээ.

ВИТНЕЙ, НЬЮЕЛ К.

Сэргээгдсэн Сүмийн анхны нэг удирдагч. Ньюел К.Витней Огайогийн Көртландад (Америкийн Нэгдсэн Улс) бишоп байсан бөгөөд хожим нь Сүмийн тэргүүлэх бишопоор үйлчилжээ (С ба Г 72:1–8; 104; 117).

ВУДРАФФ, ВИЛФОРД. Албан

Тунхаг; Тунхаглалыг *мөн үз*

Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан сайн мэдээг сэргээсний дараах Сүмийн дөрөв дэх Ерөнхийлөгч. Тэрээр 1807 онд төрж, 1898 онд нас баржээ.

Арванхоёрын Зөвлөлд дуудлага гүйцэтгэхээр дуудагджээ, **С ба Г 118:6**. Цаг хугацааны бүрэн байдалд ирэхээр хадгалагдсан сонгомол сүнснүүдийн дунд байв, **С ба Г 138:53**. Сүмд олон эхнэртэй байх ёсыг зогсоох илчлэлт хүлээн авчээ, **С ба Г АТ—1**.

ГАБРИЕЛ. Мариа, Есүсийн эх; Ноа, Библийн Патриарх; Тэнгэр элчүүдийг *мөн үз*

Даниел (Дан. 8:16; 9:21), Захариа (Лук 1:11–19; С ба Г 27:7), Мариа (Лук 1:26–38) болон бусдад (С ба Г 128:21) илгээгдсэн тэнгэр элч. Тэнгэр элч Габриел бол Хуучин Гэрээний бошиглогч Ноа болохыг Бошиглогч Иосеф Смит харуулжээ.

ГАД, ИАКОВЫН ХҮҮ. Израил; Иаков, Исаакийн хүүг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Иаков, Зилпа хоёрын (Эхл. 30:10–11) хүү. Түүний үр удмынхан Израилын нэг овог болжээ.

Гадын овог: Хүү Гаддаа өгсөн Иаковын адислалын талаар Эхлэл 49:19-ийг үз. Гадын овогт Мосегийн өгсөн адислалын талаар Дэд хууль 33:20–21-ийг үз. Эдгээр адислалуудын дагуу Гадын үр удмынхан дайчин үндэстэн болох ёстой байв. Канааны нутагт тэдэнд оногдсон газар нь Иордан голоос зүүнтэйх элбэг арвин устай, сайн бэлчээрийг багтаасан байлаа.

ГАД, ҮЗМЭРЧ. Судрууд—Алга болсон судруудыг *мөн үз*

Хуучин Гэрээнд, бошиглогч, мөн Давидын итгэлт анд хийгээд зөвлөх (1 Сам. 22:5; 2 Сам. 24:11–19). Тэрээр Давидын үйл ажиллагааны талаар нэг ном бичсэн нь алга болсон судар болжээ (Шаст. дээд 29:29).

ГАДААД ХАРАНХУЙ. Мөхлийн хүүхдүүд; Сүнсний үхэл; Там; Чөтгөрийг *мөн үз*

ГАДАС

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн зохион байгуулалтын болон захиргааны нэг нэгж. Гадас нь хэд хэдэн хэсэг буюу салбараас бүрддэг. Гадас нь ерөнхийдөө газарзүйн хилээр тогтоогдох бөгөөд Исаиа 54:2-т “Аргамжаага уртасгаж, гадсаа бөхлөгтүн” хэмээн

дүрсэлсэн майхны дүр төрхөөс үүдэлтэй ажээ. Сионы гадас бүр нь майхан буюу асрыг гадаснууд бөхлөн тогтоодгийн адил Сүмийг тогтоон барихад тусалж байдаг. Гадас нь тараагдсан Израилын үлдэгдлүүдийн цуглах газар мөн (С ба Г 82:13–14; 101:17–21).

Гадсаа бөхөлж мөн хилээ тэлэгтүн, **Моро**. 10:31 (С ба Г 82:14). Энэ нэгнээс өөр гадаснуудыг Сионд томил, **С ба Г** 109:59. Сионд мөн түүний гадаснуудад хамтдаа цуглах нь батлан хамгаалалтын тул болой, **С ба Г** 115:6 (С ба Г 101:21). Гадасны тулд өөр газрууд томилогдох ёстой, **С ба Г** 115:18. Дээд санваартнуудын чуулгын ерөнхийлөгч гадасны ерөнхийлөгчид болж мэргэшсэн байхаар тогтоов, **С ба Г** 124:133–134. Гадаснууд хүчирхэгжихийн тулд Сионы нутаг уруу яв, **С ба Г** 133:9.

ГАДИАНТОНЫ ДЭЭРЭМЧИД.

Нууц хуйвалдаануудыг *мөн үз*

Мормоны Номонд, Гадиантон хэмээх ёс бус нифай хүнээр үндэслэн байгуулагдсан дээрэмчдийн бүлэг. Тэдний байгууллага нууц хуйвалдаан хийгээд Сатаны маягийн тангаргууд дээр тулгуурлаж байв.

Гадиантон нифай үндэстнийг устгалд хүргэв, **Хил**. 2:12–13. Чөтгөр Гадиантонд нууц тангараг болон гэрээнүүдийг өгөв, **Хил**. 6:16–32. Нууц хуйвалдаанууд жаред үндэстнийг устгалд хүргэв, **Ифер** 8:15–26.

ГАЗАР ДЭЛХИЙ. Бүтээлт,

Бүтээх; Дэлхийг *мөн үз*.

Хүмүүн мөнх бус сорилтынхоо туршид ашиглахаар Есүс Христээр дамжуулан Бурханы бүтээсэн, бидний амьдардаг гараг. Үүний эцсийн хувь тавилан нь алдар сууд хүрч өргөмжлөгдөх явдал мөн (С ба Г 77:1–2; 130:8–9). Селестиел алдар суугийн тул зөв зохистой амьдарсан хүмүүсийн мөнхийн өв болох болно (С ба Г 88:14–26). Эцэг болон Хүүгийн оршихуйд тэд баяртай байх болно (С ба Г 76:62).

Хүмүүний төлөө бүтээгдсэн ажгуу: Бурхан хүмүүнд дэлхий дээрх эрх мэдлийг өгсөн, **Эхл.** 1:28 (Моце 2:28). Газар дэлхий нь Их Эзэнийх, **Ег.** 9:29 (Дуул. 24:1). Их Эзэн газар дэлхийг хүмүүний үрст өгсөн, **Дуул.** 115:16. Би газар дэлхийг бий болгож мөн үүн дээр хүнийг бүтээсэн, **Иса.** 45:12. Түүний үгийн хүчээр хүн газар дэлхий дээр ирсэн, **Иаков** 4:9. Ариун Сүнснийг өөрсдийнхөө хөтөч болгосон тэдэнд газар дэлхий өгөгдөх болно, **С ба Г** 45:56–58 (С ба Г 103:7). Сайн мэдээд дагасан тэд газар дэлхийн сайн зүйлсээр шагнагдсан билээ, **С ба Г** 59:3. Газар дэлхийн ядуус хийгээд хүлцэнгүй тэд үүнийг өвлөх болно, **С ба Г** 88:17 (Мат. 5:5; 3 Ниф. 12:5). Бид газар дэлхийг бий болгож, мөн тэднийг бид нотлох болно, **Абр.** 3:24–25.

Амьдрал оршихуй: Газар дэлхий үүрд байх болно, **Ном.** үгс 1:4. Шилэн тэнгис нь өөрийн ариусгагдсан, үхэшгүй, мөн мөнхийн байдал дахь газар дэлхий юм, **С ба Г** 77:1. Газар дэлхий ариусгагдаж мөн селестиел алдар сууд бэлтгэгдэх ёстой, **С ба Г** 88:18–19. Газар дэлхий чангаар га шууджээ, **Моце** 7:48.

Газар дэлхийн хуваагдалт: Их уснууд нэг газарт хамтдаа цуглараг, **Эхл.** 1:9. Пелегийн өдрүүдэд газар дэлхий хуваагджээ, **Эхл.** 10:25. Их уснууд ширгэсний дараа, энэ нь сонгосон газар нутаг болов, **Ифер** 13:2. Газар дэлхий үүнтэй адил энэ нь хуваагдахаас өмнө байсантай адил болно, **С ба Г** 133:24.

Газар дэлхийн цэвэршилт: Дөчин өдөр газар дэлхий дээр бороо оржээ, **Эхл.** 7:4. Газар дэлхий нь галд зориулагдан шүүлтийн төлөө хадгалагдаж байна, **2 Петр** 3:7. Өнөөдрийн дараа шатаалт ирнэ, **С ба Г** 64:24. Газар дэлхий бохир байдлаас цэвэрлэгдэхийг хүсдэг, **Моце** 7:48.

Газар дэлхийн эцсийн байдал: Газар дэлхий цаас мэт хуйлагдаж мөн үгүй болох болно, **3 Ниф.** 26:3 (С ба Г 29:23). Шинэ дэлхий шинэ тэнгэр

байх болно, **Ифер** 13:9 (С ба Г 29:23). Шилэн тэнгис нь өөрийн ариусгагдсан, үхэшгүй, мөн мөнхийн байдал дахь газар дэлхий юм, **С ба Г** 77:1. Газар дэлхий ариусгагдаж мөн селестиел алдар сууд бэлтгэгдэх ёстой, **С ба Г** 88:18–19. Энэ газар дэлхий болор дугаа адил болгогдож мөн Урим ба Тумним байх болно, **С ба Г** 130:8–9. Мянган жил газар дэлхий амрах болно, **Мосе** 7:64. Газар дэлхий шинэчлэгдэх болно, **ИТ**. 1:10.

ГАЙХАМШИГ. Итгэл;

Тэмдгүүдийг *мөн үз*

Бурханы хүчээр бий болдог ер бусын үйл явдал. Гайхамшгууд нь Есүс Христийн ажил дахь нэг чухал хэсэг юм. Эдгээр нь эдгээх, нас барагсдыг амьдралд сэргээх, мөн амилуулалтыг багтаадаг. Гайхамшгууд нь Есүс Христийн сайн мэдээний нэг хэсэг мөн. Гайхамшгууд үзүүлэгдэхийн тулд итгэл зайлшгүй чухал (Марк 6:5–6; Морм. 9:10–20; Ифер 12:12).

Фараоныг хэлэхэд, гайхамшгийг үзүүл, **Ег.** 7:9. Миний нэрээр гайхамшгийг бүтээж буй хүн дараа нь удалгүй намайг муугаар хэлж чадахгүй, **Марк** 9:39. Есүс өөрийн анхны гайхамшгийг үйлдсэн тэр газар нь Кана байлаа, **Иохан** 2:11. Би бол гайхамшгуудын Бурхан, **2 Ниф.** 27:23. Бурханы хүч гайхамшгуудыг үйлддэг, **Алма** 23:6. Тэд агуу итгэлтэй байсан учир Америк тив дэх тэдэнд Христ агуу гайхамшгуудыг үзүүлдэг байв, **3 Ниф.** 19:35. Бурхан гайхамшгуудын Бурхан байхаа болиогүй буюу, **Морм.** 9:15. Их Эзэн та нарт зарлиглахаас бусдаар гайхамшгуудыг бүү шаард, **С ба Г** 24:13–14. Гайхамшгуудыг үйлдэх бэлэнд заримд нь өгөгддөг ажгуу, **С ба Г** 46:21 (Моро. 10:12).

ГАЛ. Ариун Сүнс; Баптисм, Баптисм хүртээх; Дэлхий—Дэлхийн цэвэршилт; Тамыг *мөн үз*

Цэвэршилт, цэвэршүүлэх буюу ариусгалын бэлэгдэл. Түүнчлэн

гал нь Бурханы оршихуйн бэлэгдэл болдог.

Чиний Бурхан бол хуйхлагч гал мөн, **Дэд хууль** 4:24. Эзэн галын дөлийг өөрийн үйлчлэгчид болгодог, **Дуул.** 104:4. Түмний Эзэн тэднийг хуйхлагч галаар айлчлах болно, **Иса.** 29:6 (2 Ниф. 27:2). Эзэн галын дөлтэй хамт ирэх болно, **Иса.** 66:15. Тэрээр цэвэршүүлэгчийн галтай адил юм, **Малах.** 3:2 (3 Ниф. 24:2; С ба Г 128:24). Тэр та нарт Ариун Сүнсээр хийгээд галаар баптисм хүртээнэ, **Мат.** 3:11 (Лук 3:16). Зөв шударгыг үйлдэгчид галаар хамгаалагдан үлдэх болно, **1 Ниф.** 22:17. Ёс бусууд галаар устгагдах болно, **2 Ниф.** 30:10. Галаар хэрхэн баптисм хүртэх хийгээд Ариун Сүнсийг бид хэрхэн хүлээн авдгийг Нифай тайлбарлав, **2 Ниф.** 31:13–14 (3 Ниф. 9:20; 12:1; 19:13; Ифер 12:14; С ба Г 33:11). Баптисмаар хийгээд галаар ирэх нүглүүдийн ангижралын тухай та нар тунхаглах ёстой, **С ба Г** 19:31. Агуу хийгээд жигшүүрт сүм устгагч галаар доош хаягдах болно, **С ба Г** 29:21 Дэлхий галаар мэт сөнөх болно, **С ба Г** 43:32. Их Эзэний оршихуй нь хайлуулах гал дугаа адил байх болно, **С ба Г** 133:41. Адам галаар мөн Ариун Сүнсээр баптисм хүртэв, **Мосе** 6:66.

ГАЛАТЧУУД, ТЭДЭНД БИЧСЭН

ЗАХИДАЛ. Паул; Паулын захидлуудыг *мөн үз*

Шинэ Гэрээний нэгэн ном. Энэ нь Галат даяар амьдарч байсан Гэгээнтнүүдэд Төлөөлөгч Паулын бичсэн захидал байлаа. Гагцхүү Есүс Христийн сайн мэдээгээр амьдарснаар жинхэнэ эрх чөлөөг олж болох нь энэхүү захидлын гол сэдэв юм. Хэрэв Гэгээнтнүүд, Мосегийн хуулийг сахихыг шаарддаг Христэд итгэгч иудейчүүдийн сургаалуудыг хүлээн авах юм бол, Христэд өөрсдийн олдог эрх чөлөөг хязгаарлах буюу устгах болно. Паул уг захидалд Төлөөлөгчийн хувиарх өөрийн албан тушаалыг үндэслэн, итгэлээр ирдэг

зөв шударга ёсны сургаалыг тайлбарлаж, сүнслэг шашны үнэ цэнийг нотолжээ.

Бүлэг 1, 2-т Паул галатчуудын дундах урвалтын талаар өөрийн хүлээж авсан мэдээний талаар харамсал илэрхийлжээ. Бүлэг 3, 4 нь итгэлийн сургаалууд хийгээд ажлуудыг шүүн хэлэлцсэн байдаг. Бүлэг 5, 6 нь итгэлийн сургаалын практик үр дүнгийн талаарх номлолыг агуулжээ.

ГАЛИЛ

Эрт дээр болон өнөө үед Иордан гол болон Галилын тэнгисийн баруун тал дахь Израилын хамгийн хойт захын нутаг. Галил бол жаран миль орчим (ерэн долоон километр) урт, гучин миль (дөчин найман километр) өргөн. Эрт дээр үед энэ нутагт хамгийн сайхан хэсэг газар, түүнчлэн Израилын хамгийн их хөл хөдөлгөөнтэй хотууд байлаа. Дамаск, Египет, түүнчлэн Дорнод Израил тийш хөтөлсөн дардан замууд Галилаар дамжин өнгөрдөг байв. Энэ нутгийн онцгой сайхан цаг уур хийгээд үржил шимтэй хөрс нь чидун, улаан буудай, арвай, түүнчлэн усан зүмийн арвин ургац өгдөг байлаа. Галилын тэнгисийн дэргэдэх загасны аж ахуйнууд их хэмжээний гадаад худалдааг бий болгож, баялгийн агуу эх сурвалж болдог байв. Аврагч цаг хугацааныхаа ихэнх хэсгийг Галилд өнгөрөөжээ.

Галилд агуу гэрэл гарч ирэх болно, **Иса.** 9:1–3 (2 Ниф. 19:1–3). Есүс бүх Галилаар явахдаа номлож, зааж, мөн эдгээж байлаа, **Мат.** 4:23. Есүс амилагдсаныхаа дараа, тэрээр Галилд ирэв, **Марк** 14:28 (Иохан 21:1–14). Есүсийн тухай зар Галил даяар тархсан байлаа, **Лук** 4:14. Есүс өөрийн гайхамшгуудыг Галилын Канад эхэлсэн билээ, **Иохан** 2:11.

Галилын тэнгис: Галилын тэнгис Умард Израилд байдаг. Энэ нь Хуучин Гэрээнд түүнчлэн Чиннеретийн Тэнгис, мөн Шинэ Гэрээнд

Геннесарет буюу Тиберийн нуур хэмээн нэрлэгдсэн байдаг. Есүс нилээд хэдэн номлолыг тэнд заажээ (**Мат.** 13:2). Тэнгис нь интоор хэлбэртэй, 12.5 миль (20 километр) урт, хамгийн өргөн газартаа 7.5 миль (12 километр) байдаг. Тэнгис далайн түвшнээс 680 фут (207 метр) доор байдаг нь орчны агаарыг нилээд халуун болгодог байна. Толгодоос доош орж ирдэг хүйтэн агаар, усан дээрх халуун агаартай мөргөлдөн гэнэт шуурга дэгдээх нь олон-таа байдаг (**Лук** 8:22–24).

ГАМАЛИЕЛ. Фарисайчуудыг

мөн үз

Иудейн хуулийг мэддэг мөн заадаг байсан, Шинэ Гэрээнд гардаг нэрд гарсан фарисай хүн. Төлөөлөгч Паул түүний сурагчдын нэг байв (**Үйлс** 22:3). Тэрээр Санхедринд нэн их нөлөөтэй байжээ (**Үйлс** 5:34–40).

ГАНЦ БИЕ ЭР. Гэрлэлт,

Гэрлэхийг үз

ГАР, ГАР ТАВИЛТ. Ариун

Сүнсний бэлэг; Онцгойлон адислах; Өвчтөнийг адислах нь; Томилолт, Томилохыг *мөн үз*

Санваарын ёслолын хэсэг болгон хүн гараа хүний толгой дээр тавих үйл. Томилолт, адислалууд, өвчтөнийг адислах, Сүмийн гишүүнээр батлах, Ариун Сүнс өгөх зэрэг санваарын олон ёслол гар тавилтаар гүйцэтгэгддэг.

Эзэн зарлигласны дагуу Мосе Иошуагийн толгой дээр гараа тавив, **Тоол.** 27:18, 22–23 (Дэд хууль 34:9). Өвчтэй байсан хэдэн хүн дээр Есүс мутраа тавьж эдгээжээ, **Марк** 6:5 (Морм. 9:24). Төлөөлөгчид өөрсдөд нь туслах тэрхүү долоо дээр гараа тавив, **Үйлс** 6:5–6. Гар тавилтаар Ариун Сүнс өгөгдсөн байлаа, **Үйлс** 8:14–17. Ананиа Саул дээр гараа тавьж түүний харааг сэргээв, **Үйлс** 9:12, 17–18. Паул гараа түүн дээр тавьж, түүнийг эдгээв, **Үйлс** 28:8. Баптисмийн номлол хийгээд

гар тавилтыг Паул зааж байв, **Евр.** 6:2. Алма санваартнууд хийгээд ахлагчдыг томилов, **Алма** 6:1. Гар тавилтаар Ариун Сүнснийг хүртээх хүчийг Есүс шавь нартаа өгөв, **3 Ниф.** 18:36–37. Та нар толгой дээр нь гараа тавьсан тэдэнд Ариун Сүнснийг өгөх болно, **Моро.** 2:2. Ахлагчид хүүхдүүдийг адислахын тулд гараа тэдэн дээр тавих ёстой, **С ба Г** 20:70. Гар тавилтаар тэд Ариун Сүнснийг хүлээн авах болно, **С ба Г** 35:6 (ИТ 1:4). Ахлагчид өвчтөнүүд дээр гар тавих болно, **С ба Г** 42:44 (С ба Г 66:9). Хүүхдүүд баптисм хүртсэний дараа гар тавилтыг хүлээн авах ёстой, **С ба Г** 68:27. Санваар нь гар тавилтаар хүлээн авагддаг, **С ба Г** 84:6–16.

ГАШУУДЛЫН НОМ

Иеремиагийн бичсэн Хуучин Гэрээн дэх нэг ном. Энэ бол Иерусалим хийгээд Израил үндэстний уналтын уй гашуугийн улмаас бичигдсэн яруу найраг болон дуунуудын цуглуулга юм. Уг ном мээ 586 оны орчимд хот унасны дараа бичигджээ.

ГЕТСЕМАНИ. Цагаатгал,

Цагаатгах; Чидуны уулыг *мөн үз*

Шинэ Гэрээнд гардаг, Чидуны уулын ойролцоох цэцэрлэг. Арамей хэлээр, *гетсемани* гэдэг үг нь “чидуны шахмал” гэсэн утгатай. Иудас түүнээс урвасан тэр шөнө Есүс энэ цэцэрлэгт очжээ. Тэнд тэрээр залбирч, хүн төрөлхтний нүглүүдийн учир Гетсеманид зовон шаналж байв (**Мат.** 26:36, 39; **Марк** 14:32; **Иохан** 18:1; **Алма** 21:9; **С ба Г** 19:15–19).

ГЕТСЕМАНИЙН ЦЭЦЭРЛЭГ.

Гетсеманийг *үз*

ГИДЕОН (МОРМОНЫ НОМ)

Нифайчуудын итгэл бүхий нэг удирдагч.

Хүчирхэг хүн, мөн Ноа Хааны дайсан байв, **Моз.** 19:4–8. Лимхай Хаантай зөвлөв, **Моз.** 20:17–22. Леменчүүдийн

боолчлолоос оргон зайлах төлөвлөгөө боловсруулав, **Моз.** 22:3–9. Нехороор алагдав, **Алма** 1:8–10.

ГИДЕОН (ХУУЧИН ГЭРЭЭ)

Мидианчуудаас Израилыг чөлөөлсөн удирдагч (**Шүүгч.** 6:11–40; 7–8).

ГИЛЕАДЫН ГАВАР

Шарх эдгээхэд хэрэглэдэг халуун ногоо буюу үнэрт давирхай (**Эхл.** 43:11; **Иер** 8:22; 46:11; 51:8). Хуучин Гэрээний үед Гилеадад гавар хийдэг давирхайтай бут маш их ургадаг байсны улмаас уг гавар “Гилеадын гавар” хэмээн нэрлэгджээ (**Эхл.** 37:25; 27:17).

ГИЧИЙН ҮР

Гичийн үр бол ургамал. Уг үр нэн жижигхэн ч гэсэн үүнээс ургадаг ургамал нэн их өндөр болдог. Есүс тэнгэрийн хаант улсыг гичийн үртэй харьцуулсан байдаг (**Мат.** 13:31).

Хэрэв гичийн үр төдийхөн итгэл та нарт байвал, та нар уулыг нүүлгэж чадна, **Мат.** 17:20.

ГИШҮҮНЭЭР БАТЛАХ. Гар тавилтыг *мөн үз*

ГОГ. Есүс Христийн Хоёр дахь Ирэлт; Магогийг *мөн үз*

Магогийн хаан. Их Эзэний хоёр дахь ирэлтийн үеэр Гог Израилд халдан довтлохыг Езекиел бошигложээ (**Езек.** 38–39). Гогийн болон Магогийн тулалдаан хэмээн нэрлэгдэх өөр нэгэн тулалдаан Мянган жилийн төгсгөлд тохиох болно (**Илч.** 20:7–9; **С ба Г** 88:111–116).

ГОЛГОТА. Есүс Христ; Цовдлолтыг *мөн үз*

Голгота гэдэг нь арамай хэлээр гавал гэсэн утгатай. Энэ бол Христ цовдлогдсон тэр газрын нэр юм (**Мат.** 27:33; **Марк** 15:22; **Иохан** 19:17). Энэ газрын латин нэр нь Калвари (**Лук** 23:33).

ГОЛИАТ. Давидыг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Израилын их цэргийг тулалдаанд өдсөн Филистийн аварга эр. Давид түүний өдөлтийг хүлээн авч Их Эзэний туслалцаа-тайгаар түүнийг алжээ (1 Сам. 17).

ГОМДОЛЛОХ. Эсэргүүцлийг
мөн үз

Бурханы зорилго, төлөвлөгөө буюу үйлчлэгчдийн эсрэг үглэн бухимдах буюу гомдоллох.

Ард түмэн Мосед гомдоллов, Ег. 15:23–16:3. Иудейчүүд Есуст дургүйцэн шивнэлдэж байлаа, **Иохан** 6:41. Лемен Лемүел хоёр олон зүйлийг эсэргүүцэн бувтналдав, **1 Ниф.** 2:11–12 (1 Ниф. 3:31; 17:17). Үзээгүй юмсынхаа улмаас болж чи бүү бувтна, **С ба Г** 25:4.

ГОМОРРА. Содомыг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Их Эзэнээр устгагдсан ёс бус хот (Эхл. 19:12–29).

ГУРВАН НИФАЙ ШАВЬ.

Зөөгдсөн хүмүүн биес;

Нифайчууд; Шавийг *мөн үз*

Мормоны Номонд гардаг, Христийн сонгосон гурван нифай шавь.

Их Эзэнийг дахин иртэл тэд дэлхийдээ үлдэж, Христэд бодгалиудыг авчрахаар Хайрт Иоханд соёрхсон адислалтай адил адислалуудыг Их Эзэн эдгээр шавь нартаа амлажээ. Тэд өвчнийг мэдрэхгүй бас үхэхгүй болсон байхын тулд зөөгджээ (3 Ниф. 28).

Христ өөрийгөө ирэх хүртэл үлдэх гурван шавийн хүсэлтийг биелүүлэхээр амласан ажээ, **3 Ниф.** 28:1–9. Тэд хэзээ ч үхлийн шаналал хийгээд зовлонг амсахгүй, **3 Ниф.** 28:1–9. Тэд бүрэн баяр баясалтай байх болно, **3 Ниф.** 28:10. Тэд түр зуур тэнгэрт шүүрэгдсэн байв, **3 Ниф.** 28:13–17. Тэд хүмүүст тохинуулж мөн хавчлагыг даван гарав, **3 Ниф.** 28:18–23. Тэд Мормонд тохинуулав, **3 Ниф.** 28:24–26 (Морм. 8:10–11). Тэд харийнханд, иудейчүүдэд, тараагдсан овгуудад

хийгээд бүх үндэстэнд тохинуулах болно, **3 Ниф.** 28:27–29. Саган тэдний дээр хүчтэй байх нь үгүй, **3 Ниф.** 28:39.

ГУУЛИН МОГОЙ. Есүс Христ;
Мосег *мөн үз*

Аглаг буйдад (хорт) могойд хатгуулсан израилчуудыг эдгээхийн тулд Бурханы зарлигаар Мосегийн хийсэн хорт гуулин могой (Тоол. 21:8–9). Энэ гуулин могой саваанд бэхлэгдсэн байсан бөгөөд “үүнийг харсан хэн боловч амьдарч болохын тулд өргөгдсөн байв” (Алма 33:19–22). Аглаг буйдад могойг өргөсөн нь загалмай дээр өөрийнхөө өргөгдөхийн бэлэгдэл хэмээн Их Эзэн хэлжээ (Иохан 3:14–15). Хилэнцэт могойнуудын тухай шасти-рыг хийгээд хүмүүс хэрхэн эдгэрч байсныг хожмын үеийн илчлэлтүүд баталдаг (1 Ниф. 17:41; 2 Ниф. 25:20; Хил. 8:14–15).

ГУУЛИН ЯЛТСУУД. Ялтсуудыг
мөн үз

Эхлэлээс мөө 600 оныг хүртэлх бошиглогчдын олон бичээсийг агуулсан иудейчүүдийн цэдэг (1 Ниф. 5:10–16). Энэ цэдэг нь Иерусалимд байсан иудей ахлагчдын нэг Лебенээр хадгалагджээ. Лихай болон түүний гэр бүл аглаг буйдад байхад, Лихай энэ цэдгийг олж авахаар хөвгүүдээ Иерусалим уруу буцаан явуулжээ (1 Ниф. 3–4). (Дэлгэрэнгүй мэдээллийг Мормоны Номон дахь Мормоны Номын тухай товч тайлбараас үз.)

ГҮЙЦЭЛДҮҮЛЭХ, ХИЙХ
БИЕЛҮҮЛЭХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ.
Дуулгавартай, Дуулгавартай
байдал, Дуулгавартай дагахыг үз**ГЭГЭЭНТЭН.** Есүс Христийн
Сүм; Есүс Христийн Хожмын
Үеийн Гэгээнтнүүдийн Сүм;
Христийнхнийг *мөн үз*

Есүс Христийн Сүмийн итгэлтэй гишүүн.

Миний бурханлиг хүмүүсийг над уруу цуглуул, **Дуул.** 50:5. Иерусалим дахь Ариун хүмүүст Саул маш их ёс бусыг үйлдэв, **Үйлс** 9:1–21. Луддад оршин суудаг ариун хүмүүс дээр мөн хүрч ирэв, **Үйлс** 9:32. Ромд буй Ариун хүмүүс байхаар дуудагдсан хүмүүст нигүүдлэл ба амар тайван нь байг, **Ром** 1:7. Та нар Ариун хүмүүсийн адил нутгийн иргэд билээ, **Ефес** 2:19–21. Бурханы Гэгээнтнүүд байсан Хурганы сүмийнхнийг би болгоов, **1 Ниф.** 14:12. Эгэл хүн нь Христийн цагаатгалаар дамжин Гэгээнтэн болохоос бусдаар Бурханы дайсан байдаг, **Моз.** 3:19. Их Эзэн бибээр миний Гэгээнтнүүдийн хэрэгцээний төлөө энэ газрыг адисалсан билээ, **С ба Г** 61:17. Сатан нь Бурханы Гэгээнтнүүдтэй дайн хийдэг, **С ба Г** 76:28–29. Ирэх шүүлтгийн тулд Гэгээнтнүүдийг бэлтгэхээр хичээнгүйлэн хөдөлмөрлө, **С ба Г** 88:84–85. Гэгээнтнүүд өөрсдийнхөө эд хөрөнгийг ядуус болон зовж шаналсан хүмүүсийн төлөө өргөх ёстой, **С ба Г** 105:3. Дээрх албан тушаалуудыг бибээр тохинууллын ажил хийгээд миний Гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэхийн тулд өгсөн юм, **С ба Г** 124:143 (Ефес 4:12).

ГЭМ. Наманчлал, Наманчлахыг
мөн үз

Буруу зүйл хийсэн буюу нүглийн улмаас харамсах буюу гашуудах мэдрэмж.

Тэр нүгэл үйлдэн, гэмтэй болов, **Лев.** 6:1–6. Хэн нэгэн зохисгүйгээр ариун ёслолоос хүртэх юм бол, Есүсийн бие ба цусны буруутан болно, **1 Кор.** 11:27. Гэмтэнд үнэн хатуу байх бөлгөө, **1 Ниф.** 16:2. Бид өөрсдийн бүх гэмийн төгс мэдлэгтэй байх ёстой, **2 Ниф.** 9:14. Миний гэм зайлуулагдсан бөлгөө, **Инос** 1:6. Ухамсрын гэмшлийг авчирсан шийтгэл тогтоогдсон буюу, **Алма** 42:18. Чамайг наманчлалд доош аваачих тэрхүү зовлонгоор нүглүүд чинь чамайг зовоог, **Алма** 42:29. Та нарын зарим нь миний өмнө гэмтэй

хэдий ч би нигүүлсэнгүй байх болно, **С ба Г** 38:14. Анхны гэмийн учир Бурханы Хүү цагаатгасан билээ, **Мосе** 6:54.

ГЭМ ЗЭМГҮЙ, ГЭМ ЗЭМГҮЙ БАЙДАЛ

Гэм зэмгүй буюу нүгэлгүй.

Уналтын өмнө Адам Ева хоёр гэм зэмгүй байдалд байв, **2 Ниф.** 2:23. Гэм зэмгүйн цус нь тэдний эсрэг гэрч болон зогсох болно, **Алма** 14:11. Хүмүүний сүнс болгон эхлэлд гэм зэмгүй байв, **С ба Г** 93:38. Гэм зэмгүй нь шударга бус хүмүүсээр буруутгагдах ёсгүй, **С ба Г** 104:7. Иосеф Смит Хайрум Смит хоёр ямар ч гэмт хэрэгт буруугүй байв, **С ба Г** 135:6–7. Хүүхдүүд дэлхийн сууринаас цэвэр ариун байгаа билээ, **Мосе** 6:54.

ГЭМШСЭН ЗҮРХ. Харууссан
зүрхийг үз

ГЭР. Гэр бүлийг *мөн үз*

Гэр орон бол сайн мэдээний хийгээд гэр бүлийн үйл ажиллагааны төв байх ёстой.

Эр хүн гэртээ чөлөөтэй байж, эхнэртээ аз жаргал өгөх ёстой, **Дэд хууль** 24:5. Тэр түүнийг гэр өөд нь явуулав, **Марк** 8:26. Хүүхдүүд гэр бүлийнхнээ хүндлэхэд суралцаг, **1 Тим.** 5:4. Ухаалаг, цэвэр ариун гэрийн эзэгтэй байгтун, **Тит** 2:5. Гэртээ харьцгааж мөн миний хэлсэн зүйлүүдийг тунгаан бод, **3 Ниф.** 17:2–3. Эхнэр хүүхдүүдийнхээ төлөө, мөн гэр орныхоо төлөө тулалдахыг би тэдэнд уриалав, **Морм.** 2:23. Эцгүүд гэр орондоо хичээнгүй анхаарал халамжтай байхаар зарлиг болгуулсан билээ, **С ба Г** 93:43–44, 48–50.

ГЭР БҮЛ. Гэрлэлт, Гэрлэх; Мөнх
бус эцэг; Хүүхэд, Хүүхдүүд;
Эхийг *мөн үз*

Судруудад хэрэглэгдсэнээр гэр бүл нь нөхөр, эхнэр хоёр, хүүхдүүд

түүнчлэн заримдаа уг гэрт буюу гэр бүлийн нэг тэргүүнтэй амьдардаг бусад садан төрлүүдээс бүрддэг. Түүнчлэн гэр бүл эцэг эхийн аль нэг нь хүүхдүүдтэй, нөхөр эхнэр хоёр хүүхдүүдгүй, эсвэл ердөө ганцаараа амьдардаг ганц бие хүн байж болно.

Ерөнхий утгаараа: Газар дэлхийн бүх гэр бүл чамаар дамжин ерөөгдөнө, **Эхл.** 12:3 (Эхл. 28:14; Абр. 2:11). Би Израилын бүх гэр бүлийн Бурхан байх болно, **Иер.** 31:1. Тэнгэр дэх хийгээд газар дахь нийт гэр бүл Бурханаас нэрлэгддэг, **Ефес** 3:14–15. Адам, Ева хоёр бүх дэлхийн гэр бүлийг урагш авчрав, **2 Ниф.** 2:20. Чиний алдар суу үр удмын чинь хувьд үүрд мөнхөд үргэлжлэх болно, **С ба Г** 132:19. Би мөнх амьдралын титмийг түүнд үүрдийн дэлхийнүүдэд өгөх болно, **С ба Г** 132:55. Хүүхдүүдийг эцэг эхчүүдтэй нь лацдан холбох нь цаг хугацааны бүрэн байдлын агуу ажлын нэг хэсэг юм, **С ба Г** 138:48. Би тэднийг эрэгтэй, эмэгтэйгээр нь бүтээж: өсөн үржиж үй олон болтугай хэмээн тэдэнд хэлэв, **Моце** 2:27–28. Хүн ганцаараа байх нь сайн биш, **Моце** 3:18. Адам, Ева хоёр хамтдаа хөдөлмөрлөдөг байв, **Моце** 5:1.

Эцэг эхийн үүрэг хариуцлага: Их Эзэний замыг сахихыг Абрахам хүүхдүүддээ зарлиглах болно, **Эхл.** 18:17–19. Эдгээр үгсийг чи хүүхдүүддээ хичээнгүйлэн заах ёстой, **Дэд хууль** 6:7 (Дэд хууль 11:19). Хүүгээ хайрладаг хүн түүнийг зэмлэдэг, **Сур. үгс** 13:24 (Сур. үгс 23:13). Явах ёстой замаар нь замнуулахын тулд хүүхдийг сурга, **Сур. үгс** 22:6. Хайртай эхнэртэйгээ хамт баяр хөөртэй амьдрагтун, **Номл. үгс** 9:9. Чиний бүх хүүхэд Их Эзэний тухай заалгасан байх ёстой, **Иса.** 54:13 (3 Ниф. 22:13). Эзэний гэжээлд тэднийг авчрагтун, **Ефес** 6:1–4 (Инос 1:1). Хэрэв хэн нэгэн нь өөрснийхнөө тэтгэхгүй бол тэр хүн итгэлийг үгүйсгэдэг, **1 Тим.** 5:8. Тэрээр энэрт эцгийн бүхий л сэтгэлээр тэдэнд ухуулж байв, **1 Ниф.** 8:37.

Бидний хүүхдүүд ямар эх сурвалжийг хайж болохыг тэд мэдэхийн тулд бид Христийн тухай ярьдаг, **2 Ниф.** 25:26. Тэдний нөхрүүд болон эхнэрүүд хүүхдүүдээ хайрладаг, **Иаков** 3:7. Бие биенээ хайрлахыг мөн бие биендээ үйлчлэхийг тэдэнд заагтун, **Моз.** 4:14–15. Бүр цус урсгах хүртэл та нар гэр бүлээ хамгаалах болно, **Алма** 43:47. Та нарын эхнэр мөн та нарын хүүхдүүд адислагдахын тулд гэр бүлүүддээ залбир, **3 Ниф.** 18:21. Эцэг эхчүүд сайн мэдээг хүүхдүүддээ заах ёстой, **С ба Г** 68:25. Хүн болон өөрийн гэр бүлийг хангах үүрэгтэй, **С ба Г** 75:28. Бүх хүүхэд эцэг эхчүүдээсээ шаардах эрхтэй, **С ба Г** 83:4. Хүүхдүүдээ гэрэл ба үнэнд авчрагтун, **С ба Г** 93:40. Гэр орноо дэг журамд байлга, **С ба Г** 93:43–44, 50. Санваартнууд зөвхөн чин сэтгэлийн хайраар бусдад нөлөөлөх ёстой, **С ба Г** 121:41. Адам Ева хоёр бүх зүйлүүдийг хүүхдүүддээ мэдүүлжээ, **Моце** 5:12.

Хүүхдийн үүрэг хариуцлага: Эцэг, эхээ хүндэл, **Ег.** 20:12. Хүү минь, эцгийнхээ сургамжийг сонс, **Сур. үгс** 1:8 (Сур. үгс 13:1; 23:22). Есүс эцэг эхдээ дуулгавартай байв, **Лук** 2:51. Есүс Эцгийнхээ тааллыг гүйцэлдүүлэв, **Иохан** 6:38 (3 Ниф. 27:13). Эзэн дотор эцэг эхээ дага, **Ефес** 6:1 (Кол. 3:20). Хэрэв хүүхдүүд наманчлах аваас, таны зөвүүцэл арилах болно, **С ба Г** 98:45–48. Евагийн итгэлтэй охид үнэн хийгээд амьд Бурханыг шүтэв, **С ба Г** 138:38–39.

Мөнхийн гэр бүл: Сургаал ба Гэрээ гэрлэлтийн харилцаа хийгээд гэр бүлийн мөнхийн шинж чанарыг танилцуулсан юм. Селестиел гэрлэлт болон гэр бүл үргэлжлэх нь эхнэр, нөхрүүдийг бурхад болгох боломжийг олгодог (С ба Г 132:15–20).

ГЭР БҮЛИЙН ТҮҮХ. Нас барагсдын аврал; Угийн бичгийг үз

ГЭР БҮЛ САЛАЛТ. Гэрлэлт, Гэрлэхийг мөн үз

Иргэний болон шашны хуулийн

хүчээр дамжуулан гэрлэлтийг дуусгавар болгох. Шинэ Гэрээнд, хүмүүсийн зүрх сэтгэл хатуугийн улмаас Бурхан зарим нөхцөлд гэр бүл салалтыг зөвшөөрдөг хэдий ч, Есүсийн тайлбарласнаар эхлэлээс энэ нь байгаагүй ажээ (Мат. 19:3–12). Судрууд нь ерөнхийдөө салалтын эсрэг байхыг зөвлөдөг бөгөөд эхнэр нөхөр хоёрыг зөв шударгаар бие биенээ хайрлахыг сургадаг (1 Кор. 7:10–12; С ба Г 42:22).

ГЭРЛЭЛТ, ГЭРЛЭХ. Гэр бүл, Гэр бүл салалтыг *мөн үз*

Нөхөр, эхнэр болж байгаа эрэгтэй, эмэгтэй хүний хоорондох хууль зүйн гэрээ буюу хэлэлцээр. Бурхан гэрлэлтийг томилсон бөлгөө, (С ба Г 49:15).

Хүн ганцаар байх нь сайн биш, **Эхл.** 2:18 (Мосе 3:18). Эр хүн эхнэртэйгээ нийлэн, тэр хоёр нэгэн бие болох ажгуу, **Эхл.** 2:24 (Мат. 19:5; Абр. 5:18). Бурханы хамтад нь нийлүүлснийг хэн ч бүү салгаг, **Мат.** 19:16 (Марк 10:9). Хожмын цагт зарим нь гэр бүл болохыг хориглон, итгэлээ орхих болно, **1 Тим.** 4:1–3. Бүгд гэрлэлтийг хүндэтгэгтүн, **Евр.** 13:4. Лихийн хөвгүүд Ишмеилийн охидтой гэрлэхийг Их Эзэн зарлиглажээ, **1 Ниф.** 7:1, 5 (1 Ниф. 16:7–8). Адам, Ева хоёрыг нөхөр, эхнэр байхын тулд Бурхан бүтээжээ, **Мосе** 3:7, 18, 21–25.

Гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээ: Сайн мэдээний хууль хийгээд ариун санваарын дор хийгдсэн гэрлэлт нь мөнх бус амьдрал болон үүрд мөнхийн тулд бөлгөө. Ариун сүмд гэрлэлтээр лацдан холбогдсон зохистой эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүд нь бүх үүрд мөнхийн туршид нөхөр, эхнэр байж чадна.

Есүс гэрлэлтийн хуулийг заадаг байв, **Лук** 20:27–36. Эзэн дотор эр хүнгүйгээр эмэгтэй хүн гэж үгүй бөгөөд эмэгтэй хүнгүйгээр эр хүн гэж үгүй, **1 Кор.** 11:11. Нөхөр, эхнэр

хоёр бол амьдралын нигүүлслийг хамтран өвлөгчид мөн, **1 Петр** 3:7. Газарт лацдагдсан болгон чинь тэнгэрт лацдагдах болно, **Хил.** 10:7 (Мат. 16:19). Селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлийг хүлээж авахын тулд хүмүүн гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээнд орох ёстой, **С ба Г** 131:1–4. Хэрэв эр хүн надаар бус гэрлэх аваас, тэднийг нас барахад гэрээ хийгээд гэрлэлт нь хүчин төгөлдөр бус болно, **С ба Г** 132:15. Хэрэв эр хүн эхнэртэйгээ миний үгээр мөн шинэ бөгөөд үүрдийн гэрээгээр гэрлэж, мөн энэ нь Амлалтын Ариун Сүнсээр лацдагдах аваас, тэднийг энэ дэлхийгээс халихад энэ нь бүрэн хүчин төгөлдөр байх болно, **С ба Г** 132:19.

Өөр өөр итгэл бишрэлийн гэрлэлт: Шашны өөр өөр итгэл бишрэл, зан үйлтэй эрэгтэй хүн, эмэгтэй хүн хоёрын гэрлэлт.

Чи канаанчуудын охидоос хүүд минь эхнэр сонгох ёсгүй, **Эхл.** 24:3. Хэрэв Иаков хитчүүдийн охидоос эхнэр авбал миний амьдралд юу болох сон билээ? **Эхл.** 27:46 (Эхл. 28:1–2). Израил канаанчуудтай гэрлэх ёсгүй, **Дэд хууль.** 7:3–4. Израил канаанчуудтай гэрлэж, хуурамч бурхдыг шүтэн, мөн зүхэгдэв, **Шүүгч.** 3:1–8. Соломоны эхнэрүүд хуурамч бурхдыг шүтэн бишрэхэд түүний зүрх сэтгэлийг эргүүлэв, **Хаад, дээд** 11:1–6. Бид охидоо энэ газрын хүмүүст өгөхгүй, мөн тэдний охидыг хөвгүүд дээ авахгүй, **Нех.** 10:30. Үл итгэгчдийн хамт нэг буулганд бүү орогтун, **2 Кор.** 6:14. Нифайчууд тэдэнтэй холилдон мөн буруу ёс заншлуудад итгэхгүй байхын тулд Их Эзэн Леменчүүд дээр тэмдэг тавьжээ. **Алма** 3:6–10. Хэрэв эр хүн надаар бус гэрлэх аваас, тэднийг нас барахад гэрээ хийгээд гэрлэлт нь хүчингүй болно, **С ба Г** 132:15. Хүмүүний хөвгүүд бүр өөрсдийнхөө сонгосноор тэднийг эхнэр болгон авсан бөлгөө, **Мосе** 8:13–15.

Олон эхнэр авах ёс: Эр нөхөр нь амьд

байгаа хоёр буюу түүнээс дээш эхнэртэй гэрлэх ёс. Их Эзэн илчлэлтээр зарлиглахаас бусдаар эр хүн зөвхөн нэг эхнэртэй байх нь хууль ёсны бөлгөө (Иаков 2:27–30). Олон эхнэр авах ёс нь Хуучин Гэрээний үед хийгээд санваарын түлхүүрүүдийг атгаж асан бошиглогчийн удирдлагаар сэргээгдсэн Сүмийн эхний үед амьдралд хэрэгжиж байжээ (С ба Г 132:34–40, 45). Өнөөдөр энэ нь Сүмд хэрэгждэггүй (С ба Г АТ—1), бөгөөд нэгээс илүү эхнэртэй байх нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүний хувьд харш юм.

Сараи Хейгарыг Абрамд эхнэр болгон өгөв, **Эхл.** 16:1–11. Леа, Рахел мөн тэдний шивэгчингүүдийг Иаков эхнэрүүдээ болгон авчээ, **Эхл.** 29:21–28 (Эхл. 30:4, 9, 26). Эр хүн өөртөө өөр эхнэр авсан ч, анхныхаа эхнэрийн эзэмшлүүдийг багасгах ёсгүй. **Ег.** 21:10. Давид болон түүний хоёр эхнэр Хеброн уруу явав, **2 Сам.** 2:1–2. Олон эхнэр авахаар зарлигдуулснаа Абрахам, Исаак мөн Иаков нар хийжээ, **С ба Г** 132:37. Давид, Соломон хоёр Их Эзэнээс өөрсдийн хүлээж аваагүй тэдгээр зүйлүүдээр нүгэл үйлдсэн нь үгүй бөлгөө, **С ба Г** 132:38–39.

ГЭРЧ. Гэрчлэлийг мөн үз

Аливаа юм үнэн гэдгийн нотолгоо буюу бусад мэдэгдэл; гэрчлэл. Түүнчлэн гэрч нь хувийн мэдлэг дээр тулгуурласан ийм нотолгоо буюу мэдэгдэл хийж байгаа хэн нэгэн байж болно; энэ нь гэрчлэлээ хэлдэг хүн гэсэн үг юм.

Хуурамчаар гэрчлэх ёсгүй, **Ег.** 20:16. Сайн мэдээ бүх дэлхийд бүх үндэстнүүдэд гэрч болон номлогдох ёстой, **Мат.** 24:14 (ИС—Мат. 1:31). Та нар намайг гэрчлэх болно, **Үйлс** 1:8. Сүнс өөрөө бидний сүнсэнд гэрчилдэг, **Ром** 8:16 (1 Иохан 5:6). Та нар ямар ч үед Бурханы гэрчлэгч байх ёстой, **Моз.** 18:8–9. Бид ариун ёслолыг зарлигуудыг сахиж, Есүсийг

үргэлж дурсахаа Эцэгт гэрчлэхийн тулд хүртдэг, **3 Ниф.** 18:10–11 (Моро. 4, 5; С ба Г 20:77–79). Итгэлийн сорилтын дарааг хүртэл та нар гэрчийг үл хүлээн авах болой, **Ифер** 12:6. Гэрчлэлийн хууль: хоёр буюу гурван гэрчийн амаар үг бүхэн үндэслэгдэх болно, **С ба Г** 6:28 (Дэд хууль 17:6; **Мат.** 18:16; **2 Кор.** 13:1; **Ифер** 5:4; С ба Г 128:3). Би та нарыг Төлөөлөгчид мөн миний нэрний тусгай гэрчүүд байхаар томиллоо, **С ба Г** 27:12 (С ба Г 107:23). Дал нь харийнханд болон бүх дэлхийд тусгай гэрчүүд байхаар дуудагдав, **С ба Г** 107:25. Цэдэг хөтлөгч байг, тэрээр та нарын баптисмуудыг нүдээр гэрчлэгч байг, **С ба Г** 127:6 (С ба Г 128:2–4).

ГЭРЧЛЭЛ. Ариун Сүнс; Гэрч;

Гэрчлэхийг мөн үз

Ариун Сүнснээс өгөгдөх мэдлэг хийгээд сүнсний гэрч. Гэрчлэл нь түүнчлэн тухайн хүн хүртэж ойлгосон зүйлээ үнэн гэдгийг албан ёсоор буюу хууль ёсоор тунхагласан мэдэгдэл байж болно (С ба Г 102:26).

Аврагч маань амьдыг би мэднэ, **Иов** 19:25–26. Их Эзэнийхээ тухай гэрчлэлээс бүү ич, **2 Тим.** 1:8. Есүсийн тухай гэрчлэл бол бошиглолын сүнс юм, **Илч.** 19:10. Ямар ч цагт Бурханы гэрчлэгч бол, **Моз.** 18:9. Тэдний эсрэг шударга гэрчлэлийг үзүүлэхээс бусдаар тэднийг буцаан авах өөр зам байгаагүй, **Алма** 4:19–20. Эдгээр зүйл үнэн гэсэн гэрчлэл болж надад бүх зүйл байдаг, **Алма** 30:41–44. Итгэлийн тань сорилтын дарааг хүртэл та нар гэрчийг үл хүлээн авна, **Ифер** 12:6. Чиний оюунд амар амгалан би яриагүй бил үү? Бурханаас ирэхээс илүү агуу ямар гэрч чамд байж болох билээ? **С ба Г** 6:22–23. Мөн эдүгээ, түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол түүний талаар бидний өгөх гэрчлэл бөлгөө, **С ба Г** 76:22–24. Гэрчилж мөн хүмүүсийг сэрэмжлүүлэхийн тулд би чамайг илгээж

байна, **С ба Г** 88:81–82. Гэрчлэгчид эдүгээ нас нөгчиж, мөн тэдний гэрчлэл хүчин төгөлдөр байна, **С ба Г** 135:4–5. Тэнгэр элчүүд Эцэг болон Хүүгийн тухай гэрчилж байхыг Енох харжээ, **Моисе** 7:27. Би үзэгдэл харсан хэмээн хэлснийхээ төлөө үзэн ядагдаж мөн хавчигдал байсан ч, энэ нь үнэн билээ, **ИС—Т** 1:24–25.

ГЭРЧЛЭХ. Гэрчлэлийг мөн үз

Ариун Сүнсний хүчээр гэрчлэх; хувийн мэдлэг болон итгэлдээ тулгуурлан үнэний талаар чанд мэдэгдэл хийх.

Тайтгаруулагч миний тухай гэрчлэх болно, **Иохан** 15:26. Тэрээр бидэнд номлож мөн гэрчлэхийг зарлиглав, **Үйлс** 10:42. Гурван гэрч үнэнийг гэрчлэх болно, **2 Ниф.** 27:12. Ариун Сүнсний хүч үүнийг хүмүүний үрсийн зүрхэнд хүргэдэг, **2 Ниф.** 33:1. Судрууд Христийн тухай гэрчилдэг, **Иаков** 7:10–11 (Иохан 5:39). Миний ярьсан эдгээр зүйлүүд үнэн гэдгийг би мэднэ хэмээн би та нарт гэрчилж байна, **Алма** 5:45 (Алма 34:8). Та нар Бурханы хүчээр тэдгээрийн тухай гэрчлэх болно, **С ба Г** 17:3–5. Сүнс чамд гэрчлэх тэдгээр зүйлүүдийг чи хийх ёстой, **С ба Г** 46:7. Гэрчилж мөн сэрэмжлүүлэхийн тулд би чамайг илгээж байна, **С ба Г** 88:81.

ГЭРЭЛ, ХРИСТИЙН ГЭРЭЛ.

Ариун Сүнс; Есүс Христ; Оюун билиг, Оюун билгүүд, Ухамсар; Үнэнийг мөн үз

Есүс Христээр дамжин Бурханаас ирж мөн бүх зүйлд амьдрал хийгээд гэрлийг өгдөг бурханлиг эрч хүч буюу нөлөө. Энэ бол тэнгэр хийгээд газар дэлхий дээрх бүх зүйл удирдагддаг хууль мөн (**С ба Г** 88:6–13). Энэ нь түүнчлэн сайн мэдээний үнэнийг ойлгоход хүмүүст тусалдаг тэрчлэн аврал уруу хөтөлдөг сайн мэдээний тэрхүү зам дээр гарахад нь тэдэнд тусалдаг (Иохан 3:19–21;

12:46; Алма 26:15; 32:35; **С ба Г** 93:28–29, 31–32, 40, 42).

Христийн гэрлийг Ариун Сүнсстэй хутгах ёсгүй. Христийн гэрэл бол хүн биш юм. Энэ бол Бурханаас ирж, Ариун Сүнсийг хүлээн авахад нь хүнийг бэлтгэдэг нөлөө юм. Энэ бол бүх хүмүүсийн амьдрал дахь сайн сайхны нөлөө юм (Иохан 1:9; **С ба Г** 84:46–47).

Христийн гэрлийн нэг тунхаглал бол зөв ба буруугийн хооронд сонголт хийхэд хүнд тусалдаг ухамсар юм (Моро. 7:16). Сайн мэдээний тухай хүмүүс илүү ихийг сурах тусам тэдний ухамсар илүү мэдрэмтгий болдог (Моро. 7:12–19). Христийн гэрлийг анхаардаг хүмүүс Есүс Христийн сайн мэдээ өөд хөтлөгддөг (**С ба Г** 84:46–48).

ЭЗЭН бол миний гэрэл мөн, **Дуул.** 27:1. ЭЗЭНий гэрэлд алхацгаая, **Иса.** 2:5 (2 Ниф. 12:5). ЭЗЭН бол үүрдийн гэрэл байх болно, **Иса.** 60:19. Үнэн гэрэл дэлхийд ирдэг хүн болгоныг гэрэлтүүлдэг, **Иохан** 1:4–9 (Иохан 3:19; **С ба Г** 6:21; 34:1–3). Би бол дэлхийн гэрэл мөн, **Иохан** 8:12 (Иохан 9:5; **С ба Г** 11:28). Гэрэл болгон юу боловч сайн, **Алма** 32:35. Христ бол дэлхийн амь мөн гэрэл, **Алма** 38:9 (3 Ниф. 9:18; 11:11; Ифер 4:12). Хилэнцэтээс сайныг ялган мэддэг хүн болгонд Христийн Сүнс өгөгддөг, **Моро.** 7:15–19. Бурханаас байдаг зүйл нь гэрэл бөгөөд төгс өдрийг хүртэл улам улам хурц болон өсдөг, **С ба Г** 50:24. Сүнс нь хүн болгонд гэрлийг өгдөг, **С ба Г** 84:45–48 (**С ба Г** 93:1–2). Түүний зарлигуудыг сахьдаг тэрээр гэрэл ба үнэнийг хүлээн авдаг, **С ба Г** 93:27–28. Гэрэл ба үнэн нь хилэнцэт нэгнийг орхидог, **С ба Г** 93:37.

ГЭРЭЭ. Абрахамын гэрээ;

Санваарын тангараг ба гэрээ; Тангараг, Хуучин Гэрээ; Шинэ Гэрээ; Шинэ бөгөөд үүрдийн гэрээ; Тангаргийг, мөн үз

Бурхан ба хүмүүсийн хоорондох гэрээ боловч, тэд уг гэрээнд эн

тэнцүү байдаггүй. Бурхан гэрээнд зориулсан нөхцөлүүдийг өгдөг бөгөөд хүмүүс өөрсдөөс нь хүссэнийг хийхийг зөвшөөрдөг. Ийнхүү Бурхан хүмүүст дуулгавартай байсных нь төлөө адислалуудыг амладаг.

Гэрээгээр зарчмууд болон ёслолууд хүлээн авагддаг. Ийм гэрээнүүд хийсэн Сүмийн гишүүд тэдгээрийг хүндэтгэхээр амладаг. Жишээлбэл, гишүүд баптисм хүртэх үедээ Их Эзэнтэй гэрээнд орж, мөн ариун ёслолоос хүртсэнээр эдгээр гэрээнүүдийг шинэчилдэг. Тэд цаашдын гэрээнүүдийг ариун сүмд хийдэг. Их Эзэний хүмүүс бол гэрээт хүмүүс бөгөөд тэд Их Эзэнтэй хийсэн гэрээгээ сахиснаар агуу ихээр адислагддаг.

Би чамтай гэрээ байгуулах болно, **Эхл.** 6:18. Миний гэрээг сахь, тэгээд та нар онцгой эзэмшил болно, **Ег.** 19:5. Чи тэдэнтэй, эсвэл тэдний бурхадтай ямар ч гэрээ байгуулж болохгүй, **Ег.** 23:32. Насан туршийн гэрээнд зориулж хүндэтгэлийн өдрийг сахь, **Ег.** 31:16. Би та нартай байгуулсан гэрээгээ хэзээ ч цуцлахгүй, **Шүүгч** 2:1. Гэгээнтнүүд золиослолоор надтай гэрээ хийсэн, **Дуул.** 50:5 (С ба Г 97:8). Түүний ариун гэрээг дурс, **Лук** 1:72 (С ба Г 90:24). Бурханы хүч Их Эзэний гэрээ байгуулсан хүмүүс дээр буув, **1 Ниф.** 14:14. Абрахамтай хийсэн гэрээ хожмын өдрүүдэд биелэгдэх болно, **1 Ниф.** 15:18 (3 Ниф. 16:5, 11–12, 21:7 Морм. 9:37). Бенжамины хүмүүс тааллынх нь дагуу үйлдэнэ гэсэн гэрээнд Бурхантай ороход бэлэн байв, **Моз.** 5:5. Баптисм бол тааллынх нь дагуу үйлдэнэ гэсэн гэрээнд Бурхантай орсон гэрчлэл юм, **Моз.** 18:13. Та нар гэрээний хүүхдүүд, **3 Ниф.** 20:25–26. Тэнгэр элчүүд Эцэгийн гэрээнүүдийн ажлыг хийж мөн гүйцэлдүүлдэг, **Моро.** 7:31. Христийн цусны урсгалт нь гэрээ юм, **Моро.** 10:33. Христийн энэ сүмд харьяалагдах хүн болгон бүх зарлигууд хийгээд сүмийн гэрээнүүдийг сахин дагах ёстой, **С ба Г** 42:78. Гэрээг сахьсан тэд адислагдсан болой,

С ба Г 54:6. Энэ гэрээг зөрчдөг тэрээр өөрийн албан тушаал хийгээд сүмд байхаа алдах болно, **С ба Г** 78:11–12. Санваарыг хүлээн авах хүн бүр энэ тангараг болон гэрээг хүлээн авдаг, **С ба Г** 84:39–40. Тэд гэрээнүүдээ золиослолоор сахихад бэлэн байна, **С ба Г** 97:8. Гэрлэлтийн гэрээ мөнх байж чадна, **С ба Г** 132. Бид бүх ёслолуудад алхах болно гэсэн бидний гэрээ байх болно, **С ба Г** 136:4.

ГЭРЭЭНИЙ АВДАР. Асрыг мөн үз

Мөн Иеховагийн авдар мөн Гэрчлэлийн Авдар, Гэрээний Авдар гэдгээр мэдэгддэг энэ зүйл нь дөрвөлжин хайрцаг буюу модоор хийж алтаар бүрсэн сав юм. Энэ нь израилчуудын хамгийн эртний бөгөөд шашны хамгийн нандин бэлэг тэмдэг байв. Өршөөлийн суудал нь дэлхий дээр орших Иеховагийн газар хэмээн тооцогддог байжээ. (Ег. 25:22). Асрын дуусгавар хэсэгт авдрыг ариун газар буюу хамгийн ариун газарт байрлуулав (Хаад. дээд 8:1–8).

Мосе Бурханы зарлигласнаар авдар хийжээ, **Ег.** 25. Левийн хөвгүүд авдрыг харж хандах үүрэгтэй байв, **Тоол.** 3:15, 31. Гэрээний авдар тэднээс өмнө явав, **Тоол.** 10:33. Энэ хуулийн номыг авч гэрээний авдарт хий, **Дэд. хууль** 31:24–26. Иорданы ус гэрээний авдрын өмнө таслагдав, **Иошуа** 3:13–17; 4:1–7. Иерихог эзлэхэд гэрээний авдрыг санваартнууд авав, **Иошуа** 6:6–20. Филистүүд Бурханы авдрыг олзлон авав, **1 Сам.** 5. Бурханы авдрын учир Их Эзэн Обед-едомын гэрийг адислав, **2 Сам.** 6:11–12. Узаа дуулгаваргүйгээр авдарт гар хүрснээс Их Эзэн түүнийг алжээ, **Шаст.** дээд 13:9–12 (С ба Г 85:8). Их Эзэн Бурханы дуганыг чи барьж, гэрээний авдрыг авчир, **Шаст.** дээд 22:19. Гэрээний авдрын доторх дүрслэгдэв, **Евр.** 9:4.

ГЭТЭЛГЭГЧ. Аврагч, Есүс

Христийг мөн үз

Есүс Христ өөрийн цагаатгалаар дамжуулан, хүн төрөлхтний нүглийн

төлөөсийг төлж, бүх хүмүүсийн амилуулалтыг боломжтой болгосон учир тэрээр хүн төрөлхтний агуу их Гэтэлгэгч мөн.

Аврагч минь амьдардгийг би мэднэ, **Иов**. 19:25. Би чамд туслах болно хэмээн чиний аврагч, Израилын Ариун Нэгэн хэлдэг, **Иса**. 41:14 (**Иса**. 43:14; 48:17; 54:5; 59:20). ЭЗЭН би чиний Аврагч бөгөөд Гэтэлгэгч билээ, **Иса**. 49:26 (**Иса**. 60:16). Түүний нэрийг Есүс хэмээн дууд: учир нь тэр өөрийн хүмүүсийг нүглүүдээс нь аврах болно, **Мат**. 1:21. Хүний Хүү олны төлөө амиа золиос болгон өгөхөөр ирсэн юм, **Мат**. 20:28 (1 **Тим**. 2:5–6). Израилын ЭЗЭН Бурхан өөрийн хүмүүст айлчилж, мөн гэтэлгэв, **Лук** 1:68. Хүүгийнх нь үхлээр бид Бурхантай эвлэрүүлэгдсэн билээ, **Ром** 5:10. Бүхий л алдсуудаас биднийг гэтэлгэж болохын тулд Есүс Христ өөрийгөө бидний төлөө зориулсан юм, **Тит** 2:13–14. Есүс Христ өөрийнхөө цусаар биднийг нүглүүдээс маань угаасан билээ, **Илч**. 1:5. Гэтэлгэл нь Ариун Мессиагаар дамжин ирдэг, **2 Ниф**. 2:6–7, 26. Хүмүүний алдсууд хийгээд гэм бурууг Хүү өөр дээрээ авч, тэднийг гэтэлгэн, мөн шударга ёсны шаардлагуудыг хангасан билээ, **Моз**. 15:6–9; 18–27. Наманчлалын тул багтисм хүртсэн тэд бүгдийг гэтэлгэхээр Христ ирсэн юм, **Алма** 9:26–27. Тэрээр өөрийн хүмүүсийг гэтэлгэхийн тулд дэлхийд ирэх болно, **Алма** 11:40–41. Гэтэлгэл нь наманчлалаар дамжин ирдэг, **Алма** 42:13–26. Есүс Христ дэлхийг гэтэлгэхээр ирсэн юм, **Хил**. 5:9–12. Хүн төрөлхтнийг биеийн хийгээд сүнсний үхлээс Христ гэтэлгэсэн билээ, **Хил**. 14:12–17. Гэтэлгэл Христээр ирэв, **3 Ниф**. 9:17. Би бол өөрийн хүмүүсийг гэтэлгэхийн тулд дэлхийн үүслээс бэлтгэгдсэн тэр билээ, **Ифер** 3:14. Чиний Гэтэлгэгч Их Эзэн махан биед үхлийг үзсэн юм, **С ба Г** 18:11. Хэрэв тэд наманчилдаг байсан аваас, Христ бүхний төлөө зовлон эдэлсэн юм, **С ба Г** 19:1, 16–20.

Төрсөн Ганцаар дамжин бяцхан хүүхдүүд гэтэлгэгддэг, **С ба Г** 29:46. Дэлхийн гэтэлгэлийн төлөө би Төрсөн Ганц Хүүгээ дэлхийд илгээсэн билээ, **С ба Г** 49:5. Христ бол дэлхийн гэрэл хийгээд Гэтэлгэгч мөн, **С ба Г** 93:8–9. Нас барагдсн гэтэлгэлийн тухай үзэгдлийг Иосеф Ф.Смит хүлээн авчээ, **С ба Г** 138. Христийн цагаатгалаар дамжин бүх хүн төрөлхтөн аврагдана гэдэгт бид итгэдэг, **ИТ** 1:3.

ГЭТЭЛГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.

Аврал; Адам Ева хоёрын

Уналт; Есүс Христ; Сайн Мэдээ;

Цагаатгал, Цагаатгахыг мөн үз

Хүмүүний үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрах зорилго бүхий Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдал. Энэ нь Бүтээлт, Уналт түүнчлэн Цагаатгалыг, Бурханаас өгсөн бүх хууль, ёслолууд, мөн сургаалуудын хамт өөртөө багтаадаг. Энэ төлөвлөгөө нь өргөмжлөгдөн тийнхүү Бурхантай хамт үүрд мөнхөд амьдрах боломжийг бүх хүмүүст олгодог (2 **Ниф**. 2, 9). Судрууд бас энэ төлөвлөгөөг авралын төлөвлөгөө, аз жаргалын төлөвлөгөө, мөн нигүүлслийн төлөвлөгөө хэмээн үздэг.

Бидний гэмийн төлөө Тэр шархадсан билээ, **Иса**. 53:5 (**Моз**. 14:5). Бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн дор хүмүүнд өгөгдсөн нь үгүй, **Үйлс** 4:12. Адам дотор бүгд үхдэгчлэн, Христ дотор бүгд амьдруулагдах болно, **1 Кор**. 15:22. Итгэлээр дамжин нигүүлслээр та нар аврагддаг, **Ефес** 2:8 (2 **Ниф**. 25:23). Бурхан мөнх амьдралыг дэлхий эхлэхээс өмнө амласан юм, **Тит** 1:2. Есүс бол мөнхийн авралын зохиогч мөн, **Евр**. 5:8–9. Гэтэлгэлийн төлөвлөгөө үхэгсдийг ч хамрав, **1 Петр** 3:18–20; 4:6 (**С ба Г** 138). Агуу их Бүтээгчийн нигүүлсэнгүй төлөвлөгөөг үхэл гүйцэлдүүлдэг буюу **2 Ниф**. 9:6. Ай Бурханы маань төлөвлөгөө ямар агуу их билээ! **2 Ниф**. 9:13. Гэтэлгэлийн төлөвлөгөө нь амилуулалт хийгээд нүглүүдийн

ангиржралыг тохиолгон авчирдаг бөлгөө, **Алма** 12:25–34. Лемонайн эцэгт Аарон гэтэлгэлийн төлөвлөгөөг заав, **Алма** 22:12–14. Амюлек авралын төлөвлөгөөг тайлбарлав, **Алма** 34:8–16. Алма авралын төлөвлөгөөг тайлбарлав, **Алма** 42:5–26, 31. Бүтээлт, уналт цагаатгал хийгээд баптисмын номлолууд өнөө үеийн илчлэлтэд нотлогддог буюу, **С ба Г** 20:17–29. Уг төлөвлөгөө дэлхийн өмнө томилогдсон байв, **С ба Г** 128:22. Хүмүүний үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө, **Моце** 1:39. Энэ бол бүх хүмүүний авралын төлөвлөгөө мөн, **Моце** 6:52–62. Бид тэднийг үүгээр нотлох болно, **Абр.** 3:22–26.

ГЭТЭЛГЭГ ДЭГСЭД, ГЭТЭЛГЭЛ,

ГЭТЭЛГЭХ. Авралыг; Адам Ева

хоёрын уналт; Биеийн үхэл;

Есүс Христ; Сүнсний үхэл;

Цагаатгал, Цагаатгахыг *мөн үз*

Төлбөр төлж хүнийг боолчлолоос чөлөөлөх мэтчилэнгээр чөлөөлөх, худалдаж авах буюу барьцааны төлөөсийг төлөх. *Гэтэлгэл* нь Есүс Христийн цагаатгал хийгээд нүглээс чөлөөлсөн чөлөөлөлтөд хамаарна. Есүсийн цагаатгал нь бүх хүн төрөлхтнийг биеийн үхлээс гэтэлгэдэг. Түүнд итгэдэг хийгээд наманчилдаг хүмүүс түүний цагаатгалаар дамжин сүнсний үхлээс гэтэлгэгддэг.

Би чамайг аварсан, **Иса.** 44:22. Би тэднийг үхлээс золих болно, **Хосеа** 13:14 (Дуул. 49:15). Христийн цусаар дамжин бидэнд золилт байдаг, **Еф.** 1:7, 14 (Евр. 9:11–15; 1 Петр 1:18–19; **Алма** 5:21; Хил. 5:9–12). Их Эзэн миний богдгалийг тамаас гэтэлгэсэн, **2 Ниф.** 1:15. Гэтэлгэл нь Ариун Мессиагаар дамжин ирдэг, **2 Ниф.** 2:6–7, 26 (Моз. 15:26–27; 26:26). Тэд гэтэлгэгч хайрыг дуулав, **Алма** 5:9 (Алма 5:26; 26:13). Ёсон бусыг үйлдэгчид гэтэлгэл хийгдээгүй мэт хэвээр үлдэнэ, **Алма** 11:40–41 (Алма 34:16; 42:13; Хил. 14:16–18). Есүс Христ дэлхийн гэтэлгэлийг тохиолгон авчир-

сан билээ, **Морм.** 7:5–7. Гэтэлгэлийн хүч нь хуульгүй тэд бүгд дээр ирдэг, **Моро.** 8:22 (С ба Г 45:54). Итгэдэггүй тэд сүнсний уналтаасаа гэтэлгэгдэж чадахгүй, **С ба Г** 29:44. Бяцхан хүүхдүүд дэлхийн үүслээс гэтэлгэгдсэн байдаг, **С ба Г** 29:46. Их Эзэн өөрийн хүмүүсийг гэтэлгэсэн билээ, **С ба Г** 84:99. Иосеф Смит нас барагсдын гэтэлгэлийг үзэгдэлд харав, **С ба Г** 138. Адам Ева хоёр гэтэлгэлдээ баясав, **Моце** 5:9–11.

ДААМАЛ, АЖИЛ ҮҮРЭГ.

Дуудлага, Бурханаас

дуудагдах, Дуудахыг *мөн үз*

Бусдын ажил төрөл хийгээд хэрэг явдалд анхаарал тавьж, харж ханддаг хүн. Даамлын анхаарал тавьдаг тэр зүйлийг ажил хэрэг гэнэ. Энэ дэлхий дээрх бүх зүйл Их Эзэнд харъяалагддаг; бид түүний даамлууд юм. Бид Их Эзэнд хариуцлага хүлээсэн боловч бид ажил үүргээ Бурханаас эрх мэдэл олгосон төлөөлөгчдөд тайлагнаж болно. Бид Их Эзэнээс буюу эрх мэдэл бүхий түүний үйлчлэгчдээс үйлчлэх дуудлага хүлээн авахад уг ажил үүрэг нь сүнслэг хийгээд эд материаллаг ажил хэргийн аль аль нь байж болно (С ба Г 29:34).

Чи цөөн зүйлд итгэлтэй байлаа, би чамайг олон зүйлд захирагч болгох болно, **Мат.** 25:14–23. Хэнд их нь өгөгдөнө, түүнээс их нь шаардана, **Лук** 12:48 (С ба Г 82:3). Есүс шударга бус даамлын тухай сургаалт зүйрлэл ярих, **Лук** 16:1–8. Итгэлтэй даамал болсон тэрээр Их Эзэний хээ баяр баясалд орно, **С ба Г** 51:19. Хүн бүр өөрийнхөө ажил үүргийн тайланг өгөх ёстой, **С ба Г** 72:3–5. Итгэлтэй хийгээд ухаантай даамал бүх зүйлийг өвлөх болно, **С ба Г** 78:22. Их Эзэн бүх хүнийг дэлхийн адислалуудад даамал байх хариуцлагатай болгоно, **С ба Г** 104:11–17 (С ба Г 42:32). Ухаантай даамал байж болохын тулд хичээнгүй байцгаа, **С ба Г** 136:27.

ДАВИД. Батшеба; Дууллыг *мөн үз*
Хуучин Гэрээнд эртний Израилын хаан.

Давид нь Иуда овгийн Иессийн хүү. Тэрээр арслан, баавгай мөн Филистийн аварга биетэн Голиатыг алсан зоригтой залуу байв (1 Сам. 17). Давид нь Израилын хаан болохоор сонгогдон тосоор адислагдсан байлаа. Саулын адил өсвөр насанд хүрсэн үедээ хүн алсан гэм нүгэлтэй байсан хэдий ч, тэрээр үнэнхүү гэмших чадвартай байсан нь Саултай адил биш юм. Тийм учраас, тэрээр Юриаг алснаараа бусдад өршөөлийг олох боломжтой байжээ (С ба Г 132:39). Түүний амьдралыг дөрвөн хэсэгт хувааж болно: (1) Бетлехемд хоньчин байсан үе (1 Сам. 16–17); (2) Саул Хааны шүүхэд байсан үе (1 Сам. 18–19:18); (3) оргодол болсон үе (1 Сам. 19:18–2 Сам. 1:27); (4) Хебронд (2 Сам. 2–4) Иудагийн хаан болсон үе (2 Сам. 5–1; Хаад. дээд 2:11).

Батшебатай үйлдсэн Давидын садар самууны нүгэл нь амьдралынх нь сүүлчийн хорин жилийг сэвтүүлсэн цуврал азгүйдлийг дагуулжээ. Түүний хаанчлалын үед үндэстэн нь бүхэлдээ цэцэглэн хөгжиж байсан боловч Давид нүглүүдийнхээ үр дагавраас болж өөрөө зовсон билээ. Абсалом Адоних нараас шалтгаалан гэр бүлийн байнгын өс хонзонтой байсан бөгөөд эцэстээ энэ нь илэрхий эсэргүүцэл болжээ. Эдгээр үйл явдлууд бол Давидын нүглийн улмаас түүний талаар бошиглогч Натаны хийсэн мэдэгдлийн хэрэгжилт юм (2 Сам. 12:7–13).

Эдгээр гай зовлонгууд байсан хэдий ч, Давидын хаанчлал нь Израилын түүхийн хамгийн гайхамшигт амжилтад хүрсэн үе байв, учир нь (1) тэрээр овгуудыг нэг үндэстэн болгон нэгтгэсэн байв, (2) тэрээр улс орныхоо маргаангүй эзэмшлийг хамгаалан үлдээсэн байв, (3) Бурханы таалал Израилын хууль байхын тулд тэрээр засгийн газрыг үнэн шашин дээр тулгуурлан бий

болгожээ. Эдгээр шалтгаануудын учир Давидын хаанчлал улс үндэстний алтан үе хийгээд Мессиа ирж болох хамгийн алдар суут хэв шинжийн үе байв хэмээн хожим нь тооцогддог байжээ (Иса. 16:5; Иер. 23:5; Езек. 37:24–28).

Бүх хүмүүс зөв шударга байдалд эцсээ хүртэл тэвчих шаардлагатайг Давидын амьдрал харуулдаг. Түүнийг идэр залуу байхад, Их Эзэний өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуух хүн (1 Сам. 13:14) Сүнсээр ярьдаг хийгээд олон илчлэлт хүлээн авдаг хүн байх ёстойг түүнд хэлжээ. Гэвч Бурханы зарлигуудад дуулгаваргүй байсныхаа төлөө тэрбээр хүнд бэрх төлөөс төлсөн билээ (С ба Г 132:39).

ДАВС

Эртний дэлхийд давс нь хоол хүнсийг муудахаас хамгаалах чухал зүйл болон хэрэглэгддэг байлаа; энэ нь амьдралын гол зүйл хэмээн тооцогддог байв.

Лотын эхнэр өнгөлөг давс болов, **Эхл.** 19:26. Та нар бол дэлхийн давс, **Мат.** 5:13 (Лук 14:34; 3 Ниф. 12:13). Их Эзэний гэрээт хүмүүс дэлхийн давс хэмээн тооцогддог, **С ба Г** 101:39–40. Хэрэв Гэгээнтнүүд хүмүүний аврагч биш аваас, амтаа алдсан давс лугаа адил болно, **С ба Г** 103:9–10.

ДАЙН. Амар амгалан, Энх тайвныг *мөн үз*

Тулалдаан буюу зэвсэгт мөргөлдөөн; зэвсгээр тулалдах. Гэр бүл, эд хөрөнгө, эрх, боломжоо болон эрх чөлөөгөө хамгаалах зөвхөн сүүлчийн арга болж байгаа тохиолдолд Их Эзэн дайныг өөрийн Гэгээнтнүүдэд хүлээн зөвшөөрдөг билээ (Алма 43:9, 45–47).

Моронай өөрийн хүмүүс, өөрийн эрх, эх орноо болон шашин шүтлэгээ хамгаалахыг эрэлхийлсэн болой, **Алма** 48:10–17. Иосеф Смит дайны тухай илчлэлт болон бошиглол хүлээн авчээ, **С ба Г** 87. Дайнаас

татгалзаж, амар амгаланг тунхагла, **С ба Г** 98:16, 34–46. Хүн өөрсдийгөө, найз нөхдөө, газар нутгаа засаг захиргаагаа хамгаалснаар зөвтгөгддөг гэдэгт бид итгэдэг, **С ба Г** 134:11. Хуулийг дагаж, хүндэтгэн, дэмжихэд бид итгэдэг, **ИТ** 1:12.

ДАЙСАГНАЛ. Атаархал; Өс хонзон; Хайрыг *мөн үз.*

Судруудад харшилдаан, дайсагнал ба үзэн ядалт.

Би чамайг тэр эмэгтэйтэй өс хонзонтой болгох болно, **Эхл.** 3:15 (Мосе 4:21). Махан биеийн бодол бол Бурханы эсрэг дайсагнал юм, **Ром** 8:7. Ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал мөн, **Иаков** 4:4. Тэр өдөр дайсагнал миний нүүрний өмнөөс байхгүй болно, **С ба Г** 101:26.

ДАЙСАН. Чөтгөрийг үз

ДАЛ. Мелкизедек санваар; Төлөөлөгчийг *мөн үз*

Мелкизедек санваарт томилогдсон эрэгтэйчүүдийн албан тушаал. Өнөөдөр, Далын Чуулгууд нь төлөөлөгчийн эрх мэдэл өгөгдсөн Сүмийн Ерөнхий эрх мэдэлтнүүд боловч, томилогдсон Төлөөлөгчид биш юм. Тэд бүх цагаа тохинуулалд зориулдаг.

Их Эзэн бусад далыг томилов, **Лук** 10:1. Дал нь сайн мэдээг номлож мөн Есүс Христийн тусгай гэрч байхаар дуудагддаг, **С ба Г** 107:25–26. Дал нь Арванхоёрын удирдлага дор Сүмийг барих хийгээд үүний бүхий л үйл хэргийг бүх үндэстэнд зохицуулахад Их Эзэний нэрээр ажилладаг, **С ба Г** 107:34. Хэрэв хөдөлмөр шаардлагатай бол өөр далыг, бүр долоон удаа далыг сонго, **С ба Г** 107:93–97. Далын чуулга нь бүх дэлхийд миний нэрийг гэрчлэх аялагч ахлагчдын тулд үндэслэн байгуулагддаг, **С ба Г** 124:138–139.

ДАМАСК

Сирийн эртний хот.

Дамаск нь цөлийн захад үржил

шимтэй тал нутагт Барада мөрний элбэг дэлбэг усаар хангагддаг. Энэ хот судруудад олон дахин дурдагддаг (**Эхл.** 15:2-оос эхлээд). Амилсан Их Эзэн Паулд үзэгдэх үед тэрээр Дамаск уруу явж байв (**Үйлс** 9:1–27; 22:5–16; 26:12–20; 2 Кор. 11:32–33).

ДАМАСКИЙН АНАНИА.

Паулыг *мөн үз*

Паулаар баптисм хүртсэн, Дамаск дахь Христийн шавь (**Үйлс** 9:10–18; 22:12).

ДАН. Израил; Исаакийн хүү Иаковыг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Рахелын шивэгчин Билха, Иаков хоёрын хүү (**Эхл.** 30:5–6).

Даны овог: Данд өгсөн Иаковын адислалыг, Эхлэл 49:16–18-аас үз. Даны овогт Мосегийн өгсөн адислалыг Дэд хууль 33:22-оос үз. Тэд Канаанд суурьшсаныхаа дараа Даны овог жижигхэн боловч маш их үржил шимтэй хэсэг газрыг хүлээн авчээ (**Иош.** 19:40–48). Үүнийгээ аморичууд (**Шүүгч.** 1:34) болон филистинчүүдээс (**Шүүгч.** 13:2, 25; 18:1) хамгаалахад тэдэнд маш хэцүү байв. Чухамдаа үүнээс болж данчууд Палестинаас (**Шүүгч.** 18) умард зүгт Лаишт нүүж очиж, мөн уг хотыг Дан хэмээн нэрлэжээ. Уг хот Данаас бүр Беершебаг хүртэл үргэлжилдэг байсан Палестины умард хязгаар хэмээн нэрд гарсан юм.

ДАНИЕЛ

Хуучин Гэрээний Даниелын номны гол дүр; Бурханы бошиглогч бөгөөд агуу итгэлтэй хүн.

Түүний эцэг эхийн тухай юу ч мэдэгдээгүй хэдий ч, тэрээр сурвалжит гаралтай бололтой (**Дан.** 1:3). Тэрээр Вавилонд олзлогдохдоо Белтешазар гэдэг нэртэй болжээ (**Дан.** 1:6–7). Шашин шүтлэгийн шалтгааны улмаас Даниел болон өөр гурван олзлогдогч хааны зоогноос татгалзжээ (**Дан.** 1:8–16).

Даниел зүүд тайлдаг (**Дан** 2; 4) хүчээрээ Небухаднезар болон Дарийн

тааллыг олжээ. Мөн тэрээр ханан дээрх гар бичмэлийг уншиж, хөрвүүлсэн байна (Дан 5). Дайснууд нь түүний эсрэг хуйвалдаж, мөн тэрээр арслангийн торонд хаягдсан боловч түүний амийг Их Эзэн аварсан билээ (Дан. 6).

Даниелын ном: Уг ном хоёр хэсэгтэй: Бүлэг 1–6 нь Даниел болон түүний гурван хамтрагчийн түүх; бүлэг 7–12 нь Даниелын харсан бошиглолын үзэгдэл. Ном нь Бурханд үнэнч байхын чухлыг зааж мөн итгэлтнүүдийг Их Эзэн адисалдгийг тодотгон харуулжээ.

Номны хамгийн гол хувь нэмэр нь Хаан Небухаднезарын зүүдний тайлал болно. Зүүдэнд, хожмын өдрүүдэд Бурханы хаант улс уулнаас таслагдсан чулуу дугаа адилаар дүрслэгдсэн байна. Чулуу нь бүх дэлхийг дүүргэтэл урагш өнхрөх болно (Дан. 2; мөн С ба Г 65:2-ыг үз).

ДАРИ. Бабел, Вавилоныг мөн үз

Хуучин Гэрээнд, Белшазарыг үхсэний дараа Вавилонд хаанчилж байсан Медесийн хаан (Дан. 5:31; 6:9; 25–28; 9:1; 11:1).

ДАРУУ ТӨЛӨВ БАЙДАЛ. Даруу,

Даруу байдлыг мөн үз

Даруу, төлөв түвшин хийгээд номхон дөлгөөн зан төлөв буюу байдал. Даруу хүн илүүц зүйлүүд хийгээд сайрхлаас зайлсхийдэг.

Адам болон түүний эхнэрт зориулж, Бурхан арьсан дээл хийжээ, **Эхл.** 3:21 (Моце 4:27). Эмэгтэйчүүд өөрсдийгөө даруу түвшин байдлаар чимэн хувцасладаг, **1 Тим.** 2:9. Ухаалаг, цэвэр ариун, гэрийн эзэгтэй байгун, **Тиг** 2:5. Олон нь өөрсдийнх нь өмсгөл чимэглэл үнэтэйн улмаас бардамналд өргөгдсөн ажгуу, **Иаков** 2:13. Бүх өмсгөлөө энгийн даруу байлгагун, **С ба Г** 42:40. Цэвэр ариун хийгээд ариун журамтай байхад бид итгэдэг, **ИТ** 1:13.

ДАРУУ, ДАРУУСГАХ, ДАРУУ

БАЙДАЛ. Бардамнал; Номхон,

Номхон дөлгөөн байдал; Сул тал; Харууссан зүрх; Ядууг мөн үз

Номхон, үг авдаг байх буюу номхон дөлгөөн, үг авдаг байх нөхцөл. Даруу байдал нь Бурханаас бидний хамааралтай байдлыг ойлгон хүлээн зөвшөөрч, түүний таалалд захирагдах хүслийг багтаадаг.

Бурхан чамайг даруусгахын тулд чамайг дөчин жилийн турш цөлд удирдсан, **Дэд хууль** 8:2. Би мацаг барилтаар өөрийн бодгалийг даруусгаж байв, **Дуул.** 35:13. Тэнэг хөгшин хаанаас, ядуу ч гэсэн ухаалаг хүүхэд дээр, **Номл. үгс** 4:13. Их Эзэн даруу түүнтэй хамт оршдог, **Иса.** 57:15. Хэн өөрийгөө энэ бяцхан хүүхэд адил даруу болгоно, тэр нь тэнгэрийн хаанчлалд хамгийн агуу нь болно, **Мат.** 18:4. Өөрийгөө даруусгадаг тэр нь өргөмжлөгдөх болно, **Мат.** 23:12 (Лук 14:11; 18:14). Есүс өөрийгөө даруусган, үхэлд дуулгавартай байв, **Филип.** 2:8 (Лук 22:42; 23:46). Бурхан бардамнагчдыг эсэргүүцэж, даруу хүмүүст нигүүлслээ хайрладаг, **1 Петр** 5:5–6 (2 Ниф. 9:42). Өөрсдийгөө даруу байдлын гүнд даруусга, **Моз.** 4:11 (2 Ниф. 9:42; 3 Ниф. 12:2). Та нар хангалттай даруу байдаг уу? **Алма** 5:27–28. Хүмүүсийн илүү даруу хэсэг нь даруу байдалдаа улам хүчирхэг болж байв, **Хил.** 3:33–35. Тэд даруу байж болохын тулд би хүмүүст сул доройг өгдөг, **Ифер** 12:27. Даруу байдал баптисм хүртэхэд нийцдэг, **С ба Г** 20:37. Миний өмнө өөрсдийгөө даруусга, мөн та нар намайг үзэж мөн намайг байдгийг мэдэх болно, **С ба Г** 67:10. Чи даруу бай, мөн Их Эзэн залбирлуудад чинь чамд хариулах болно, **С ба Г** 112:10. Үл хайхрагч тэрээр өөрийгөө даруусгаснаар мэргэн ухаанд суралцаг, **С ба Г** 136:32. Даруу тэднийг гэгээрүүлэхийн тулд Сүнс урагш илгээгддэг, **С ба Г** 136:33.

ДАХИН БИЙ БОЛГОХ,

СЭРГЭЭХ. Сайн мэдээний

Сэргээлтийг мөн үз

Авч явагдсан буюу алга болсон юм

буюу нөхцөл байдлыг буцаан бий болгох.

Сүнс мөн бие төгс хэлбэрээр дахин нэгдэх болно, **Алма** 11:43–44. Сэргээлт нь хилэнцтийн хариуд хилэнцтийг зөв шударгын хариуд зөв шударгыг буцаан авчрах явдал мөн, **Алма** 41:10–15. Арван овгийн сэргээлтэд, түүнчлэн дэлхий диваажингийнхаа алдар сууд сэргэх болно гэдэгт бид итгэдэг, **ИТ** 1:10 (С ба Г 133:23–24).

ДАХИН ТӨРӨХ, БУРХАНААС

ТӨРӨХ. Баптисм, Баптисм хүртээх; Бурханы хөвгүүд охид; Төрсөн; Хөрвөгч, Хөрвүүлэг; Христийн хүүхдүүд; Эгэл хүнийг мөн үз

Их Эзэний Сүнстэй байх нь хүний зүрх сэтгэлд агуу өөрчлөлт болон нөлөөлснөөр тэрээр ёсон бусыг дахин хийх хүсэлгүй болж, харин үүний оронд Бурханы зүйлсийг эрж хайх хүсэлтэй болдог.

Би чиний дотор шинэ сүнснийг тавина, **Езек.** 11:19 (Езек 18:31; 36:26). Христийн нэрэнд итгэсэн бүхэн дусаар биш, харин Бурханаар төрдөг, **Иохан** 1:12–13. Хүн ус болон Сүнснээс төрөхгүй аваас Бурханы хаант улсад орж чадахгүй, **Иохан** 3:3–7. Бид Бурханы үгээр дахин төрж чадна, **1 Петр** 1:3–23. Бурханаас төрсөн хэн ч нүгэлд үргэлжлүүлэн үйлдэхгүй, **ИСО**, **1 Иохан** 3:9. Бурханаас төрсөн юу ч дэлхийг ялдаг, **1 Иохан** 5:4. Тэдгээр Христээр төрсөн хүмүүс Бурхантай гэрээлсэн, **Моз.** 3:19; 5:2–7. Бүх хүмүүс дахин төрөх шаардлагатай; тийм ээ, Бурханаас төр, **Моз.** 27:25–26 (Алма 5:49). Та нар сүнслэг байдлаараа Бурханаас төрсөн үү? **Алма** 5:12–19. Хэрэв та нар дахин төрөөгүй бол та нар тэнгэрийн хаант улсыг өвлөж чадахгүй, **Алма** 7:14. Миний үгэнд итгэсэн хэн боловч, бүр ус болон Сүнсээр надаас төрөх болой, **С ба Г** 5:16. Та нар тэнгэрийн хаант улсад дахин төрөх шаардлагатай, **Мосе** 6:59.

ДЕБОРА

Хуучин Гэрээнд, Израилыг шүүсэн мөн канаанчуудын эсрэг Баракийг дэмжсэн эмэгтэй бошиглогч (Шүүг. 4). Дебора болон Баракийн дуун Израил боолчлолоос чөлөөлөгдсөний баярыг тэмдэглэдэг байв (Шүүг. 5).

ДЕЗҮРЭТ. Жаредчуудыг мөн үз

Мормоны Номонд, балт зөгий гэсэн утгатай жаред үг (Ифер 2:3).

ДЕЛИЛА. Филистийг мөн үз

Хуучин Гэрээнд Самсоныг хууран мэхэлж мөн барьж өгсөн филист эмэгтэй (Шүүгч. 16)

ДИВААЖИН. Тэнгэрийг мөн үз

Энэ амьдралаас хальж одсон зөв шударга сүнснүүд биеийнхээ амилуулалтыг хүлээдэг сүнсний дэлхийн нэг хэсэг. Энэ бол аз жаргал хийгээд амар амгалангийн нэг нөхцөл мөн.

Диваажин нь судруудад тэрчлэн сүнснүүдийн дэлхий (Лук 23:43), селестиел хаант улс (2 Кор. 12:4), мөн дэлхийн алдар суу нь мандсан Мянган жилийн нөхцөл гэсэн утгаар хэрэглэгддэг (ИТ 1:10).

Ялан дийлэх түүнд Бурханы диваажингийн голд байх амьдралын модноос идэх боломжийг би өгөх болно, **Илч.** 2:7. Бурханы диваажин зөв шударгыг үйлдэгчдийн сүнснүүдийг чөлөөлдөг, **2 Ниф.** 9:13. Зөв шударгыг үйлдэгчдийн сүнснүүд нь диваажин хэмээн нэрлэгддэг аз жаргалын байдалд хүлээн авагддаг бөлгөө, **Алма** 40:11–12. Есүсийн шавь нар, гурваас бусад нь бүгд Бурханы диваажинд одсон байв, **4 Ниф.** 1:14. Бурханы диваажинд амрахаар би удахгүй явна, **Моро.** 10:34. Диваажин дахь зөв шударга сүнснүүдэд Христ тохинуулав, **С ба Г** 138.

ДИКОН. Аароны санваарыг мөн үз

Төлөөлөгч Паулын үе дэх Сүмийн үйлчлэлийн дуудлага (Филип. 1:1;

1 Тим. 3:8–13) мөн Аароны санваарын албан тушаал (С ба Г 20:38, 57–59; 84:30, 111; 107:85).

ДОРОМЖЛОЛ, ДОРОМЖЛОХ.

Бүдүүлэг үг хэллэг;

Уучлагдашгүй нүглийг *мөн үз*

Бурханы болон ариун нандин зүйлсийн талаар хүндэтгэлгүй буюу бишрэлгүйгээр ярих.

Нүглүүдийг уучлах эрхийг шаардсаны улмаас (Мат. 9:2–3; Лук 5:20–21), тэрээр өөрийгөө Бурханы Хүү хэмээн нэрлэсний улмаас (Иохан 10:22–36; 19:7), түүнчлэн тэнгэрийн хүчний баруун гар талд суухыг мөн тэнгэрийн үүлэн дунд ирэхийг нь тэд харах болно хэмээн тэр хэлсний улмаас (Мат. 26:64–65) үг хэлээр доромжилсон хэмээн иудейчүүд Есүсийг хэдэнтээ буруутгажээ. Хэрв тэрээр өөрийнхөө хэлсэн тэр бүхний дагуу үнэхээр тийм байсан бол эдгээр буруутгалууд үнэн байх байлаа. Санхедрины өмнө шүүх хурал дээр хуурамч гэрчүүд түүний эсрэг мэдүүлсэн буруутгал нь Бурханы ариун сүмийн эсрэг доромжлол байв (Мат. 26:59–61). Христийн тухай төгс мэдлэгийг хүлээн авсны дараа түүнийг санаатайгаар үгүйсгэх явдал болох Ариун Сүнсний эсрэг доромжлол бол уучлагдашгүй нүгэл мөн (Мат. 12:31–32; Марк 3:28–29; С ба Г 132:27).

Их Эзэний нэрийг доромжилсон хүн үхэх болно, **Лев.** 24:11–16. Их Эзэний дайснууд түүний нэрийг доромжлохоор үлдсэн байх нь үгүй, **С ба Г** 105:15. Их Эзэний эсрэг доромжилсон хүмүүс дээр өс хонзон ирэх болно, **С ба Г** 112:24–26.

ДУР ТАЧААЛ, ХҮСЭЛ ТАЧААЛ.

Тачаадалт; Тачаангуйг *мөн үз*

Ямар нэг юманд зохисгүйгээр ихэд хүсэн шунах.

Тэр эмийн гоо үзэсгэлэнг зүрхэндээ бүү хүс, **Сур.** үгс 6:25. Эмэгтэй хүнийг тачаалан хардаг хүн бүр садар самууныг аль хэдийнээ үйлд-

сэн байдаг, **Мат.** 5:28 (3 Ниф. 12:28). Эрчүүд бие биендээ тэмүүлэх хүсэлд шатжээ, **Ром** 1:27. Тэд өөрсдийн хүслийн дагуу өөрсөддөө багш нарыг бөөгнөрүүлэх болно, **2 Тим.** 4:3–4. Лебен бидний эдийг үзээд, үүнд шунаа, **1 Ниф.** 3:25. Нүднийхээ тачаал шуналын төлөө дахин бүү яв, **Алма** 39:3–4, 9. Эмэгтэй хүнийг тачаангуйгаар хардаг тэрээр итгэлийг үгүйсгэдэг, **С ба Г** 42:23. Өөрсдийн бүхий л шунаг хүслүүдээс татгалзагтун, **С ба Г** 88:121.

ДУРСАМЖИЙН НОМ.

Амьдралын ном; Удмын бичгийг *мөн үз*

Ном нь удмынхаа ажлуудыг цэдэглэсэн Адамаар эхэлжээ; мөн бошиглогч болон итгэлтэй гишүүдээр тэр цагаас хойш хадгалагдан үлдсэн аливаа ижил төрлийн цэдгүүд юм. Адам болон түүний хүүхдүүд сүнсний нөлөөгөөр бичсэн Дурсамжийн ном мөн үе удмыг агуулсан удмын номыг хөтөлдөг байжээ (**Мосе** 6:5, 8). Тийм цэдгүүд бидний эцсийн шүүлтийг шийдвэрлэхэд нэг хэсэг нь болж болох юм.

Дурсамжийн ном бичигдсэн байв, **Малах.** 3:16–18 (3 Ниф. 24:13–26). Дурсамжийн номонд бичигдсэн байгаа нь олдохгүй бүх хүмүүст тэр өдөр өв олдох нь үгүй, **С ба Г** 85:9. Нас барагсад номнуудад агуулагдсан өөрсдийнхөө ажлуудын дагуу шүүгдсэн байлаа, **С ба Г** 128:7. Бидний нас барагсдын цэдгийг агуулдаг номыг танилцуулцгаая, **С ба Г** 128:24. Дурсамжийн ном хөтлөгдөж байлаа, **Мосе** 6:5–8. Бидэнд дурсамжийн ном бий, **Мосе** 6:46. Абрахам өөрийн үр удмын цэдгийг бичихийг хичээж байв, **Абр** 1:31.

ДУУ ХООЛОЙ.

Илчлэлтийг *мөн үз*
Судруудад хэрэглэгдсэнээр, заримдаа Их Эзэн болон түүний элч нарын ярьсан сонсогдохуйц захиас байдаг. Сүнсний дуу хоолой нь сонсогдохгүй бөгөөд тэрчлэн зүрх сэтгэл хийгээд оюунд чиглэсэн байж болно.

Эзэн Бурханы дуу хоолойг Адам Ева хоёр сонсчээ, **Эхл.** 3:8 (Моце 4:14). Их Эзэн Елиатай намуун дуугаар ярив, **Хаад.** дээд 19:11–13. Зөв шударгыг үйлдэгчид Сайн Хоньчны дуу хоолойг дагадаг, **Иохан** 10:1–16. Үнэний хүн бүр миний дууг сонсоно, **Иохан** 18:37. Би Сүнсний дуу хоолойг дагасан, **1 Ниф.** 4:6–18. Дуу хоолой над дээр ирж Инос, нүгэл чинь өршөөгдсөн гэв, **Инос** 1:5. Энэ нь төгс зөөлөн дуу хоолой байсан бөгөөд сэтгэлийн угт хүртэл нэвтрэв, **Хил.** 5:29–33 (3 Ниф. 11:3–7). Миний дуу хоолой ч байна уу, миний үйлчлэгчдийн ч дуу хоолой байна уу, энэ нь адил юм, **С ба Г** 1:38. Ариун Сүнсээр хөдөлгөгдөн тэд юу ч ярьсан Их Эзэний дуу хоолой болой, **С ба Г** 68:2–4. Миний дуу хоолойг дуулгавартай дагах бүх хүмүүн миний нүүрийг харж би байдаг гэдгийг мэдэх болно, **С ба Г** 93:1.

ДУУДАХ, БУРХАНААС ДУУДАГДСАН, ДУУДЛАГА.

Ажил үүрэг, Даамал;
Сонгогдох (үйл үг), Сонгогдсон
(тэмдэг нэр), Сонгосон,
Сонгох; Томилох, Томилолт;
Эрх мэдлийг мөн үз

Бурханаас дуудагдах гэдэг нь зохих ёсоор эрх мэдэл олгогдсон түүний Сүмийн удирдагчдаас томилолт буюу урилга хүлээн авах, эсвээс түүнд аль нэг хэлбэрээр үйлчлэх гэсэн үг юм.

Тэрээр түүний дээр гараа тавин, түүнд үүрэг хариуцлагыг даалгав, **Тоол.** 27:23. Би чамайг бошиглогч болгон томилжээ, **Иер.** 1:5. Би та нарыг сонгож мөн та нарыг томилсон юм, **Иохан** 15:16. Паул Төлөөлөгч байхаар дуудагдсан байжээ, **Ром** 1:1. Ямар ч хүн энэ хүндлэлийг өөртөө авдаг бус, харин Бурханаас дуудагдсан хүн авдаг, **Евр.** 5:4. Есүс Бурханаас Мелкизедекийн журмын дагуу дуудагдав, **Евр.** 5:10. Би Илчлэлтийн мөн бошиглолын суу билгийн дагуу, Бурханы үгийг номлохоор дуудагдсан юм, **Алма**

8:24. Санваартнууд дэлхийн үүслээс бэлтгэгдэн мөн дуудагдсан болой, **Алма** 13:3. Хэрэв та нар Бурханд үйлчлэх хүсэлтэй аваас та нар дуудагдсан болой, **С ба Г** 4:3. Чамайг би дуудсан тэр ажилд чанд шаргуу зогсогтун, **С ба Г** 9:14. Чи дуудагдах хүртлээ номлохоор дуудагдсан гэж бодох хэрэггүй, **С ба Г** 11:15. Ахлагч нар сонгосон хүмүүсийн цугларалтыг тохиолгон авчрахаар дуудагддаг, **С ба Г** 29:7. Хэрэв тэд томилогдоогүй бол хэн ч миний сайн мэдээг номлох буюу миний Сүмийг барих ёсгүй, **С ба Г** 42:11. Олон нь дуудагдаг боловч цөөхөн нь сонгогддог, **С ба Г** 121:34. Хүмүүн Бурханаас дуудагдах ёстой, **ИТ** 1:5.

ДУУДЛАГА БА СОНГОГДОГСОД.

Сонгогдогсдыг мөн үз

Христийн зөв шударга дагалдагчид өргөмжлөлийн баталгааг олж авдаг сонгогдогсдын дунд тоологдож болно. Энэ дуудлага ба сонгууль нь наманчлал болон баптисмаар эхэлдэг. Энэ нь тэд “урагш тэмүүлэн, Христийн үгнээс зооглон мөн эцсээ хүртэл тэвчсэн” үед бүрэн дүүрэн болдог (2 Ниф. 31:19–20). Судрууд энэ явцыг дуудлага ба сонгогдсоноо баттай болгох хэмээн нэрлэдэг (2 Петр 1:4–11; С ба Г 131:5–6).

Та нар надад санваартнуудын хаанчлал болно, **Ег.** 19:5–6 (Илч 1:6). Эхлэлээс Бурхан авралын төлөө сонгогдогсодтой байсан, **2 Тес.** 2:13. Өөрсдийнхөө дуудлага ба сонгуулийг баттай болгохын тулд хичээнгүй бай, **2 Петр** 1:10. Их Эзэн та нарыг өөрийнх байлгахаар лацдаж болох буюу, **Моз.** 5:15. Та нарт мөнхийн амьдрал байх болно хэмээн би та нартай гэрээ хийж байна, **Моз.** 26:20. Итгэлтэй санваартнууд Сүм ба хаант улс, мөн Бурханы сонгосон хүмүүс болдог, **С ба Г** 84:33–34. Бошиглолын илүү баттай үг нь мөнх амьдралд лацдагдахаа хүн мэдэх нь болой, **С ба Г** 131:5–6. Би өргөмжлөлийг чинь та нар дээр лацдах болно, **С ба Г** 132:49.

ДУУЛАЛ. Давид; Дуулах;
Хөгжмийг *мөн үз*

Бурханлигаар нөлөөлөгдсөн яруу найраг буюу дуулал.

Дууллын ном: Олон нь Христийн тухай дууллуудын цуглуулгыг агуулдаг, Хуучин Гэрээний нэг ном. Дууллын номноос Шинэ Гэрээнд байнга иш татсан байдаг.

Дууллын номыг Давид бичжээ. Дууллууд нь Бурханд өргөх магтаал болон бичигджээ. Олныг нь хөгжимд тохируулжээ.

ДУУЛАЛ. Дуулах; Хөгжмийг
мөн үз

Бурханы магтаалын дуун.

Их Эзэнийг Гетсеманид очихоос өмнө Арванхоёр Төлөөлөгч нэгэн дуулал дуулав, **Мат.** 26:30. Их Эзэн ариун дууллуудыг сонгуулахаар Эмма Смитийг дуудав, **С ба Г** 25:11. Зөв шударгыг үйлдэгчдийн дуу нь надад хандсан залбирал бөгөөд тэдний тэргүүн дээр адислалаар хариулагдах болно, **С ба Г** 25:12. Дуу болоод хөгжмөөр Их Эзэнийг магт, **С ба Г** 136:28.

ДУУЛАХ. Дуулал; Хөгжмийг
мөн үз

Бурханыг дуу болон хөгжимт шүлгээр бишрэн шүтэх буюу магтах.

Их Эзэнд дуулья, **Шаст. дээд** 16:23–36 (Дуул. 96). Их Эзэнд дуулж мөн талархал өргө, **Дуул.** 30:4. ЭЗЭНД баясалтайгаар хашгирагтун, **Дуул.** 100:1. Тэд магтуу дуулсныхаа дараа тэд Чидуны уул өөд явцгаав, **Мат.** 26:30. Ариун Сүнс дуулахад удирдав, **Моро.** 6:9. Зөв шударгын дуу нь надад залбирал болтой, **С ба Г** 25:12. Хэрэв чи аз жаргалтай байх аваас Их Эзэнийг дуугаар магтагтун, **С ба Г** 136:28.

ДУУЛГАВАРТАЙ,
ДУУЛГАВАРТАЙ БАЙДАЛ,
ДУУЛГАВАРТАЙ ДАГАХ.
Адислагдсан, Адислал, Адислах;

Алхх, Анхаарах; Бурхантай хамт алхах; Баяр хөөр; Бурханы зарлигууд; Хуулийг *мөн үз*

Сүнсний утгаараа, дуулгавартай байдал бол Бурханы тааллыг хэрэгжүүлэх явдал мөн.

Ноа ийнхүү үйлдэж, Бурханы өөрт нь тушаасан бүхнийг ёсоор гүйцэтгэжээ, **Эхл.** 6:22. Абрахам Бурханыг дуулгавартай дагав, **Эхл.** 22:15–18. Эзэний айлдсан бүгдийг бид ёсоор гүйцэтгэх болно, **Ег.** 24:7. Тиймийн тулд сонсогтун, Ай Израил, мөн үүнийг дагаж мөрдөгтүн, **Дэд хууль** 6:1–3. Эзэн Бурханаа хайрлан, түүний үгийг дуулгавартай дага, **Дэд хууль** 30:20. Дуулгавартай дагах нь золиослолоос илүү дээр, **1 Сам.** 15:22. Бурханаас эмээж, мөн түүний зарлигуудыг сахь, **Номл. үгс** 12:13–14. Тэнгэрийн хаант улсад хүн болгон орохгүй, харин Эцэгийн тааллыг биелүүлдэг хүн орно, **Мат.** 7:21 (3 Ниф. 14:21). Хэрэв хэн нэгэн нь түүний тааллыг үйлдэхийг хүсч байгаа бол сургаал нь Бурханаас юм гэдгийг тэрээр мэдэж байх ёстой, **Иохан** 7:17. Бид хүнийг дагахаасаа илүү Бурханыг дагах ёстой, **Үйлс** 5:29. Хүүхдүүд ээ, эцэг эхээ дага, **Ефес** 6:1 (Кол. 3:20). Би явж мөн Их Эзэний зарлигласан тэр зүйлийг биелүүлэх болно, **1 Ниф.** 3:7. Би Сүнсний дуу хоолойг дагав, **1 Ниф.** 4:6–18. Хүмүүний үрс Бурханы зарлигуудыг дагавал тэрээр тэднийг асарна, **1 Ниф.** 17:3. Хилэнцэт сүнснийг дагахаас та нар болгоомжил, **Моз.** 2:32–33, 37 (С ба Г 29:45). Тэд дагахаар шийдсэн тэр сүнснийхээ дагуу хүмүүс өөрсдийн шагналыг хадгаж бөлгөө, **Алма** 3:26–27. Хүмүүн өөрсдийн чөлөөт хүсэл зоригоор олон зүйлийг хийх ёстой, **С ба Г** 58:26–29. Түүний мутарт үл гэмших мөн түүний зарлигуудыг эс дагах тэднээс бусад хүмүүсийг Бурхан юунд ч гомдоох нь үгүй, **С ба Г** 59:21. Миний хэлснийг та нар хийхэд Их Эзэн бибээр үүрэг хүлээдэг, **С ба Г** 82:10. Дуу хоолойг минь дагадаг

бодгаль болгон миний нүүрийг харж мөн би байдгийг мэдэх болно, **С ба Г** 93:1. Тэд дуулгавартай байдлыг сурах хүртлээ хүмүүс гэсгээн цээрлүүлэгдэх ёстой, **С ба Г** 105:6. Бид ямар ч адислалыг Бурханаас авлаа гэхэд энэ нь батлагдсан тэрхүү хуульд дуулгавартай байснаар ирдэг, **С ба Г** 130:21. Адам дуулгавартай байлаа, **Моце** 5:5. Тэд Их Эзэний зарлиглах бүх зүйл юуг ч гэсэн хийх нь үү гэдгийг харахын тулд бид тэднийг нотлох болно, **Абр.** 3:25.

ДҮР ТӨРХ

Хүний нүүрэн дээрх ерөнхий илрэл, ихэнхдээ сүнслэг зан төлөв болон оюун санааны байдалд тусгаа олодог.

Тэдний царайны хувирал өөрсдийнх нь эсрэг гэрчилдэг, **Иса.** 3:9. Хааны царай цонхийж, бодлууд нь түүнийг түгшээв, **Дан.** 5:6. Түүний дүр аянга лугаа адил байв, **Мат.** 28:3. Нүүр нь нар лугаа адил байв, **Илч.** 1:16. Та нар түүний дүрслэлийг өөрсдийн царай төрхөндөө хүлээж авсан уу, **Алма** 5:14, 19. Хааны царай төрх өөрчлөгдсөнийг Аммон харав, **Алма** 18:12. Баяртай зүрх сэтгэл хийгээд хөгжилтэй дүр төрхтэйгээр, **С ба Г** 59:14–15. Түүний төрх байдал нарны гэрлээс ч илүү хурцаар гялалзаж байлаа, **С ба Г** 110:3.

ДЭД ХУУЛЬ. Пентатеухыг мөн үз

Хуулийн давталт гэсэн утгатай бөгөөд Хуучин Гэрээний тав дахь ном.

Дэд Хууль нь Мосегийн хувиралтаас дөнгөж өмнө Моабын тал нутагт түүний авчирсан сүүлчийн гурван гар бичмэлийг агуулдаг. Эхний гар бичмэл (бүлэг 1–4) бол оршил. Хоёр дахь гар бичмэл (бүлэг 5–26) хоёр хэсэгт хуваагддаг, (1) бүлэг 5–11 нь Арван хууль болон тэдгээрийн бодит тайлбар бөгөөд (2) бүлэг 12–26 нь бүхэл номны цөм хэлбэр болсон хуулийн түлхүүр юм. Гурав дахь гар бичмэл нь (бүлэг 27–30) Бурхан Израил хоёрын хоорондох

гэрээний чанд шинэчлэл болон дуулгавартай байснаар ирэх адислаалууд хийгээд дуулгаваргүй байснаас ирдэг зүхлийг агуулдаг. Бүлэг 31–34 нь левичүүдэд өгөгдсөн хуулийг, Мосегийн дуулал болон сүүлчийн адислал, түүнчлэн Мосе салан явсныг дүрсэлжээ.

ДЭЛХИЙ. Бабел; Вавилон; Газар дэлхий; Мөнх бус, Мөнх бус байдлыг мөн үз

Газар дэлхий; мөнх бус хүнийг сорих газар. Зүйрлэсэн утгаараа, Бурханы зарлигуудыг дагадаггүй хүмүүс.

Мөнх бус оршихуй: Дэлхийд та наргай зовлонтой байх болно, **Иохан** 16:33. Үхлээс бүү ай; учир нь энэ дэлхийд чиний баяр байсал дүүрэн биш юм, **С ба Г** 101:36.

Зарлигуудыг дагадаггүй хүмүүс: Ёс бусынх нь улмаас би дэлхийг шийтгэх болно, **Иса.** 13:11 (2 Ниф. 23:11). Хэрэв дэлхий та нарыг үзэн ядах аваас, энэ нь өмнө нь намайг үзэн ядсаныг та нар мэднэ, **Иохан** 15:18–19. Агуу хийгээд нүсэр барилга нь дэлхийн бардамнал байв, **1 Ниф.** 11:36. Дэлхий алдаст боловсорч байна, **С ба Г** 18:6. Өөрийгөө дэлхийгээс толбогүй байлга, **С ба Г** 59:9. Итгэлтэй хийгээд тэвчдэг тэр нь дэлхийг ялах болно, **С ба Г** 63:47. Та нар дэлхийн маягаар амьдрах ёсгүй, **С ба Г** 95:13.

Дэлхийн төгсгөл: Би шинэ дэлхий бүтээнэ: мөн урьдын юмс санагдахгүй байх болно, **Иса.** 65:17 (Илч. 21:1; ИТ 1:10). Энэ дэлхийн төгсгөлд ээрлэг өвсийг цуглуулан галд шатаах болно, **Мат.** 13:40, 49 (Мал. 4:1; Иаков 6:3). Талбайгаа би галд шатаагдахаар болгоно, **Иаков** 5:77 (С ба Г 64:23–24). Дэлхийн төгсгөлд Их Эзэн Сатан болон түүний ажлуудыг устгах болно, **С ба Г** 19:3. Дэлхий сөнөх болно, гэвч амилуулагдана, **С ба Г** 88:25–26. Их Эзэн дэлхийн төгсгөлийг Еноход үзүүлжээ, **Моце** 7:67.

ДЭЛХИЙН ТӨГСГӨЛ. Дэлхий— Дэлхийн төгсгөлийг мөн үз

ДЭЛХИЙН ШИНЖ ЧАНАР.

Бардамнал; Баялгууд; Мөнгө;
Хоосон, Хоосон зүйлийг мөн үз

Шударга бус хүслүүд болон сүнсний зүйлүүдийг умартан цаг зуурын баялгууд хийгээд материаллаг зүйлсийн төлөөх хүчин чармайлтууд.

Учир нь хүн бүх дэлхийг олж авсан ч, амиа алдвал ямар ашиг байх билээ? **Мат.** 16:26. Тэд зүрх сэтгэлээ дэлхийн хоосон зүйлүүд дээр суурилуулжээ, **Алма** 4:8 (Алма 31:27). Энэ дэлхийн зүйлүүдийг хойш тавь, **С ба Г** 25:10. Хүмүүсийн зүрх сэтгэл дэлхийн зүйлүүд дээр маш ихээр тавигдсан байна, **С ба Г** 121:35.

ДЭЭГҮҮР ӨНГӨРСНИЙ БАЯР.

Бурханы Хурга; Сүүлчийн зоогийг мөн үз

Устгагч тэнгэр элч гэрийнх нь дээгүүр өнгөрөн, тэднийг египетчүүдээс чөлөөлснийг дурсан санахад нь Израилын хүүхдүүдэд туслахын тулд Дээгүүр Өнгөрсний Баярын найрыг бий болгожээ (Ег. 12:21–28; 13:14–15). Эрт дээр үед Израилыг аврах тэмдэг хэмээн цусыг нь ашигладаг байсан ямар ч согоггүй хурганууд нь, золиослол нь бүх хүн төрөлхтнийг гэтэлгэсэн Есүс Христ, Бурханы Хурганы бэлэгдэл юм.

Энэ бол Дээгүүр Өнгөрсний ёслол мөн, **Ег.** 12:43. Есүс болон түүний Төлөөлөгчид Дээгүүр өнгөрсний баярыг Сүүлчийн зоог дээр хийв, **Мат.** 26:17–29 (Марк 14:12–25). Ер-төнцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харагтун, **Иохан** 1:29, 36. Бидний Дээгүүр өнгөрөх баярын хурга болох Христ ч гэсэн бидний төлөө золиослогдсон юм, **1 Кор.** 5:7. Христийн цус болох гэмгүй бөгөөд толбогүй хурганы цусаар бид золигдсон юм, **1 Петр.** 1:18–19. Дэлхийн нүглүүдийг зайлуулах Бурханы Хурганд итгэлтэй байг-тун, **Алма** 7:14. Мэргэн Ухааны Үгээр амьдардаг Гэгээнтнүүд Израилын хүүхдүүдийн хувьд хам-гаалагдах болно, **С ба Г** 89:21. Хурга

дэлхийн сууринаас алагдсан буюу, **Мосе** 7:47.

ДЭЭД ЗӨВЛӨЛ

Арванхоёр дээд санваартны зөвлөл.

Сүм сэргээгдсэн эхний үед, дээд зөвлөл гэдэг нэр томьёо нь хоёр өөр удирдах байгууллага: (1) Сүмийн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга (С ба Г 107:33, 38); мөн (2) өөрсдийнхөө гадас дотор үйлчилдэг дээд зөвлөлд хамаатай байв (С ба Г 102; 107:36).

ДЭЭД САНВААР. Мелкизедек санваарыг үз

ДЭЭД САНВААРТАН. Аароны санваар; Мелкизедек санваарыг мөн үз

Санваарын албан тушаал. Судрууд дээд санваарыг хоёр утгаар (1) Мелкизедек санваарын албан тушаал; түүнчлэн (2) Мосегийн хуулиар, Аароны санваартны тэргүүлэх албан тушаалтан гэсэн утгаар хэрэглэсэн байдаг.

Эхнийх нь утга агуу дээд санваартан болох Есүс Христийн хувьд хэрэглэгддэг. Адам болон бүх патриархууд түүнчлэн дээд санваартнууд байлаа. Өнөөдөр, тэргүүлэгч гурван дээд санваартан Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийг бүрдүүлж, бусад бүх санваартнууд болон Сүмийн гишүүдийг тэргүүлдэг. Үүнээс гадна зохистой олон эрэгтэйчүүд өнөөдөр Сүм даяар зохих журмын дагуу дээд санваартнаар томилогддог. Дээд санваартнууд нь бишпоор дуудагдан, томилогдож, мөн онцгойлон адислагдаж болно, (С ба Г 68:19; 107:69–71).

Хоёр дахь утгаараа, Мосегийн хуулиар Аароны санваарын тэргүүлэх албан тушаалтан дээд санваартан хэмээн дуудагддаг байжээ. Уг албан тушаал үе залгамжлагддаг байсан бөгөөд Аароны гэр бүлийнхний доторх ууган хөвгүүдээр дамжин ирсэн бөгөөд Аарон өөрөө Аароны жаягийн дагуу анхны дээд санваартан байжээ (Ег. 28; 29; Лев. 8; С ба Г 84:18).

Мелкизедек бол хамгийн дээд Бурханы санваартан байв, **Эхл.** 14:18 (Алма 13:14). Дээд санваартнууд дэлхийн үүслээс дуудагдан мөн бэлтгэгдсэн билээ, **Алма** 13:1–10. Дээд санваартнууд сүнсний зүйлүүдийг гүйцэтгэдэг **С ба Г** 107:10, 12, 17.

ДЭЭШЛЭН ОДОЛТ. Есүс Христ;

Есүс Христийн Хоёр дахь
Ирэлтийг *мөн үз*

Амилалтаасаа хойш дөчин өдрийн дараа Аврагч газар дэлхийгээс явсан хэлбэр. Дээшлэн одолт нь Чидуны уулын цэг дээрээс, шавь нар нь тэнд байхад тохиожээ (**Марк** 16:19; **Лук** 24:51). Ирээдүйд Их Эзэн “ийм маягаар” буцаж ирэх болно гэдгийг тэр үед тэнгэрээс хоёр тэнгэр элч гэрчилжээ (**Үйлс** 1:9–12).

ЕВА. Адам; Адам, Ева хоёрын

Уналт; Еденийг *мөн үз*

Энэ дэлхий дээр амьдарсан анхны эмэгтэй хүн (**Эхл.** 2:21–25; 3:20). Тэр бол Адамын эхнэр байв. Еврей хэлээр энэ нэр амьдрал гэсэн утгатай бөгөөд Ева бол дэлхий дээрх анхны эх гэсэн утгыг илэрхийлдэг ажээ. (**Мосе** 4:26.) Тэр болон анхны хүн Адам хоёр бүх хүмүүн төрөлхтний мөнхийн дэвшлийг боломжтой болгоход гүйцэтгэсэн үүргийнхээ төлөө мөнхийн алдар сууг хуваалцах болно.

Ева уруу татагдаж, хориглогдсон жимснээс иджээ, **Эхл.** 3 (2 **Ниф.** 2:15–20; **Мосе** 4). Ева уналтын зайлшгүйг болон гэтэлгэлийн баяр хөөрийг хүлээн зөвшөөрчээ, **Мосе** 5:11–12. Ерөнхийлөгч Иосеф Ф.Смит сүнсний дэлхийн тухай үзэгдэлдээ Еваг харжээ, **С ба Г** 138:39

ЕВАНГЕЛИСТ. Патриарх,

Патриархын; Патриархын
адислалуудыг *мөн үз*

Есүс Христийн сайн мэдээний баярт мэдээнүүдийг гэрчилдэг мөн тунхагладаг хүн. Евангелист нь пат-

риарх байсныг Иосеф Смит заадаг байв. Патриархууд нь патриархын адислалууд гэгддэг тусгай адислалуудыг өгөхийн тулд Арванхоёр Төлөөлөгчийн удирдлаган дор дуудагдаж, мөн томилогддог.

Их Эзэн заримыг нь элч, заримыг нь эш үзүүлэгч, заримыг нь сайн мэдээг тунхаглагчаар дууддаг, **Ефес** 4:11. Сайн мэдээг дэлгэрүүлэгчийн ажлыг хий, **2 Тим.** 4:5. Төлөөлөгчид, бошиглогчид, пасторууд, багш нар, евангелистуудад бид итгэдэг, **ИТ** 1:6

ЕВРЕЙ ХЭЛ. Израилыг *мөн үз*

Израилын хүүхдүүдийн ярьдаг селист бүлгийн хэл.

Израилчууд Вавилоны боолчлолоос буцаж ирэх хүртлээ еврей хэлээр ярьдаг байв. Энэ үеэс арамей хэл өдөр тутмын харилцааны хэл болжээ. Есүсийн үед еврей хэл эрдэм боловсролтой хүмүүсийн, хуулийн, пашны, утга зохиолын хэл байв.

ЕВРЕЙЧҮҮД, ТЭДЭНД БИЧСЭН

ЗАХИДАЛ. Паул; Паулын
захидлуудыг *мөн үз*

Шинэ Гэрээний нэг ном. Мосегийн хуулийн чухал заалтууд Христэд гүйцэлдсэн хийгээд Христийн сайн мэдээний илүү дээд хууль үүнийг орлох боллоо гэдэгт Сүмийн иудей гишүүдийг итгүүлэхийн тулд Паул энэ захидлыг тэдэнд бичжээ. Паул гурав дахь номлолынхоо төгсгөлд Иерусалимд (мэ 60 оны үед) эргэж ирэхдээ Сүмийн олон иудей гишүүн Мосегийн хуулинд итгэсэн хэвээр байгааг мэджээ (**Үйлс** 21:20). Энэ бол Мосегийн хуулийн зарим ёслолууд Христэд итгэгч харийнханы авралын хувьд шаардлагатай биш болсныг тогтоосон Иерусалим дахь Сүмийн чуулганаас хойш дор хаяж арван жилийн дараа болсон байлаа. Тийнхүү яагаад еврейчүүд Мосегийн хуулийг цаашид хэрэглэх ёсгүйг өөрсдийнх нь судраар мөн эрүүл харуул учир үндэслэлээр тэдэнд харуулахын тулд Паул нэн

удалгүй энэхүү захидлыг тэдэнд бичжээ.

Бүлэг 1, 2 нь Есүс бол тэнгэр элчүүдээс илүү агуу гэдгийг тайлбарладаг. Бүлэг 3–7 нь Есүсийг Мосетой болон Мосегийн хуультай тэрээр энэ хоёрын алинаас нь ч илүү агуу юм гэдгийг гэрчилдэг. Түүнчлэн Мелкизедек санваар Аароньхаас илүү агуу юм гэдгийг эдгээр бүлгүүд заадаг. Бүлэг 8–9 нь Мосегийн ёслолууд хүмүүсийг Христийн тохинуулалд хэрхэн бэлтгэсэн хийгээд Христ хэрхэн шинэ гэрээний зууч болсныг дүрслэн харуулдаг (Алма 37:38–45; С ба Г 84:21–24). Бүлэг 10 нь хичээл зүтгэл хийгээд итгэл бишрэлийг ухуулдаг. Бүлэг 11 нь итгэлийн тухай хүүрнэл юм. Бүлэг 12 нь сэрэмжлүүлэг болон мэндчилгээнүүдийг агуулдаг. Бүлэг 13 нь гэрлэлтийн эрхэм хүндэтгэлтэй чанар хийгээд дуулгавартай байхын ач холбогдлын тухай өгүүлдэг.

ЕГИПЕТ

Африкийн зүүн хойд буланд оршдог улс. Египетийн ихэнх нь үржил шимгүй цөл газар. Ихэнх оршин суугчид нь ойролцоогоор 550 миль урт (890 километр) Нилийн Хөндийд амьдардаг.

Эртний Египет нь баян чинээлэг бөгөөд цэцэглэн хөгжсөн байлаа. Нийтийн хэрэглээний агуу барилга байгууламжууд, түүний дотор услалтын сувгууд; батлан хамгаалахын хүчирхэг хотууд; хаадын хөшөөнүүд; ялангуяа дэлхийн гайхамшгууд хэвээр байгаа пирамидан бунхан мөн ариун сүмүүдийг барьж босгожээ. Хэсэг хугацаанд Египетийн засгийн газар санваарын патриархын жаягийн үлгэр жишээ байв (Абр. 1:21–27).

Абрахам болон Иосеф Египет уруу гэр бүлээ өлсгөлөнгөөс аврахын тулд хөдлөв, *Эхл.* 12:10 (*Эхл.* 37:28). Иосеф Египетэд худалдагдав, *Эхл.* 45:4–5 (1 Ниф. 5:14–15). Иаков Египет уруу хөдөлжээ, *Эхл.* 46:1–7. Мосе Израилын хүүхдүүдийг Еги-

петээс гаргав, *Ег.* 3:7–10; 13:14 (Евр. 11:27; 1 Ниф. 17:40; Мосе 1:25–26). Египет ёсон бусыг бэлэгддэг, *Езек.* 29:14–15 (Хосе 9:3–7; Абр. 1:6, 8, 11–12, 23). Мариатай хамт Египет уруу зугт хэмээн тэнгэр элч Иосефт хэлжээ, *Мат.* 2:13 (Хосе 11:1).

ЕГИПЕТУС

Ноагийн хүү Хамын эхнэр охин хоёрын нэр. Халдеи хэлээр энэ нэр нь хориглогдсон буюу Египет гэсэн утгыг илэрхийлдэг (Абр. 1:23–25).

ЕГИПЕТЭЭС ГАРСАН НЬ.

Пентатеухыг мөн үз

Хуучин Гэрээнд, израилчууд Египетээс гарч явсныг дүрслэн харуулдаг, Мосегийн бичсэн ном. Египетээс Гарсанд цэдэглэгдсэнээр Израилын эхэн үеийн түүхийг: 1. Хүмүүс Египетэд боолчлогдсон нь, 2. Мосегийн удирдлагаар тэд Египетээс гарсан нь, 3. Тэд шашны амьдралдаа мөн улс төрийн амьдралдаа Бурханд үйлчлэх үйлчлэлд өөрсдийгөө зориулсан нь гэсэн гурван хэсэгт хувааж болно.

Эхний хэсэг бүлэг 1–15 нь Египет дахь Израилын эсэргүүцэл; Эхэн үеийн түүх хийгээд Мосегийн дуудлага; Египетээс гарсан нь хийгээд Дээгүүр өнгөрөх баярыг бий болгосон нь; мөн Улаан Тэнгис уруу аялсан, Фараогийн цэргийг сүйрүүлсэн хийгээд Мосегийн ялалтын дууг тайлбарладаг;

Хоёр дахь хэсэг, бүлэг 15–18 нь Израилын гэтэлгэл хийгээд Улаан Тэнгисээс Синай уруу хийсэн аялын тухай үйл явдлууд; Мараогийн гашуун ус, бөднө шувууд хийгээд маннаг өгсөн, Хүндэтгэлийн өдрийг сахисан, Рефидимд гайхамшигтайгаар ус бэлэглэсэн, түүнчлэн тэнд амалекчуудтай тулалдсан; Иетро буудалд хүрч ирсэн хийгээд ард түмний иргэний засгийн газрын тухай өгүүлдэг.

Гурав дахь хэсэг, бүлэг 19–40 нь Синайд болсон онцгой хүндэтгэлтэй үйл явдлуудын үеэр Израилыг

Бурхан ариулан адисалсан талаар өгүүлдэг. Их Эзэн хүмүүсийг санваартнуудын хаант улс хийгээд ариун үндэстэн болгон онцгойлон адисалж, тэрээр Арван Зарлигийг өгчээ; асар, үүний тавилга, тэндэх шүтлэгийн талаар зааврууд өгөв. Дараа нь хүмүүс алтан тугал шүтэж нүгэл үйлдсэн тухай шастир, түүнчлэн эцэст нь асар барих болон үүний үйлчлэлийн тулд байх хангамжийн тухай шастир үргэлжилдэг.

ЕДЕН. Адам; Еваг *мөн* үз

Еденд дорно зүгт цэцэрлэг байхаар тогтоогдсон, бидний анхны эцэг эх Адам Ева хоёрын орон гэр (Эхл. 2:8–3:24; 4:16; 2 Ниф. 2:19–25; Мосе 3, 4; Абр. 5). Хориглогдсон жимснээс идэж, Мөнх бус болсны дараа Адам Ева хоёр Еденээс хөөгдсөн билээ (Мосе 4:29). Хожмын үеийн илчлэлт Еденийн цэцэрлэгийн тухай библийн шастирыг баталдаг. Энэ цэцэрлэг одоогийн Хойд Америк тивд байсан гэсэн чухал мэдээлэл энэ шастир дээр нэмэгдсэн билээ.

ЕДЕНИЙН ЦЭЦЭРЛЭГ. Еденийг үз

ЕЗЕКИЕЛ

Хуучин Гэрээн дэх Езекиелийн номыг бичсэн бошиглогч. Тэрээр Задокийн гэр бүлийн санваартан бөгөөд Небухаднезараар боолчлолд аваачигдсан иудейчүүдийн нэг байв. Тэрээр иудейчүүдийн цөлөгдөгсдийн хамт Вавилонд суурьшиж, мэв 592–570 оныг хүртэл хорин хоёр жилийн хугацаанд бошигложээ.

Езекиелийн ном: Езекиелийн номыг дөрвөн тусгаар хэсэгт хувааж болно. Бүлэг 1–3 нь Бурханы үзэгдэл хийгээд Езекиел үйлчлэхээр дуудагдсан тухай өгүүлдэг; бүлэг 4–24 нь Иерусалимын тухай санал дүгнэлтүүд болон яагаад эдгээр нь өгөгдсөнийг өгүүлдэг; бүлэг 25–32 нь үндэстнүүдийн талаарх санал дүгнэлтүүдийг тунхагладаг бөгөөд бүлэг 33–48 нь хожмын үеийн Израйлын тухай үзэгдлүүдийг өгүүлдэг.

ЕЗРА

Хэсэг иудейчүүдийг Вавилоны боолчлолоос Иерусалимд буцааж авчирсан, Хуучин Гэрээний санваартан бөгөөд хуулийн багш. (Езра 7–10; Нех. 8,12.) мэв 458 онд тэрээр, явахыг хүссэн Иудейн аль ч цөлөгдөгсдийг авч явах зөвшөөрлийг Персийн хаан Артаксерксаас олж авчээ. (Езра 7:12–26.)

Езрагийн үеийн өмнө, санваартнууд хууль хэмээн нэрлэгддэг байсан бичмэл судруудын цуглуулгыг уншихад бараг л нэлэнхүйд нь хяналт тавьдаг байв. Иудей хүн болгонд судруудыг хүртээмжтэй болгоход Езра тусалжээ. Хуулийн номыг илээр унших нь эцэстээ иудей үндэстний амьдралын гол төв болжээ. Их Эзэний хуулийг эрэлхийлж, үүнийг дуулгавартай дагаж, үүнийг бусдад заахад зүрх сэтгэлээ бэлтгэдэг түүний хувийн үлгэр дуурайллаас Езрагийн агуу сургаал гардаг байсан биз ээ. (Езра 7:10).

Езрагийн ном: Бүлэг 1–6 нь Езраг Иерусалимд ирэхээс жараас наян жилийн өмнө болсон үйл явдлууд, мэв 537 оны Сирийн тогтоол, тэрчлэн иудейчууд Зеруббавелын удирлага дор эргэж ирснийг дүрсэлдэг. Бүлэг 7–10 нь Езра Иерусалим уруу хэрхэн явсныг харуулдаг. Тэр, өөрийн нөхдийн хамт замгаалалтын төлөө мацаг барин залбирдаг байв. Зеруббавелын удирдлага дор өмнө нь олон иудей хүн Иерусалимд ирж, мөн эмэгтэйчүүд гэрээнээс гадуур гэрлэн, тийнхүү өөрсдийгөө бузарласныг олж мэджээ. Езра тэдний төлөө залбирч, тэдгээр эхнэрүүдээс нь салган тэднийг гэрээн дор тавьжээ. Езрагийн хожуу үеийн түүх Нехемиагийн номонд байдаг.

ЕЛИ. Хуучин Гэрээний

бошиглогч Самуелыг *мөн* үз

Их Эзэн Самуелыг бошиглогч болгохоор дуудах үед байсан Хуучин Гэрээний дээд санваартан бөгөөд шүүгч (1 Сам. 3). Хөвгүүдийнхээ ёс

бус явдалд хүлцэнгүй хандсаных нь төлөө Их Эзэн түүнийг зэмлэжээ (1 Сам. 2:22–36; 3:13).

ЕЛИА. Аврал; Елиас; Лацдалт;
Лацдахыг мөн үз

Хожмын өдрүүдэд лацдалтын хүчний түлхүүрүүдийг Иосеф Смит Оливер Каудери хоёрт олгохоор эргэж ирсэн Хуучин Гэрээний бошиглогч. Елиа өөрийнхөө үед Израилын Умард Хаант Улсад тохинуулж байв (Хаад. дээд 17—Хаад. дэд 2). Тэрээр Их Эзэнд итгэх агуу итгэлтэй байсан бөгөөд олон гайхамшигийг үйлдсэн нь цэдэглэгдсэн байдаг. Тэр гурван жил хагасын туршид борооноос урьдчилан сэргийлжээ. Тэрээр нэгэн хөвгүүнийг нас барагсдаас босгож, тэнгэрээс галыг доош нь дуудав (Хаад. дээд 17–18). Иудей хүмүүс Малахийн бошиглосончлон түүнийг эргэж ирнэ хэмээн Елиаг хүлээсээр байгаа билээ (Малах. 4:5). Нээлттэй хаалга, сул суудал түүнийг ямагт хүлээж байдаг Иудейн Дээгүүр Өнгөрөх Баярт, тэрээр уригдсан зочин хэвээр үлдсэн юм.

Елиа Мелкизедек санваарын лацдалтын хүчийг атгадаг байсан бөгөөд Есүс Христийн үеийн өмнөх сүүлчийн ийм бошиглогч байсан хэмээн Бошиглогч Иосеф Смит хэлжээ. Тэрээр Хувиралтын Уулан дээр Мосегийн хамт хүрч ирэн санваарын түлхүүрүүдийг Петр, Иаков, Иохан нарт өгчээ (Мат. 17:3). Тэрээр Мосе болон бусдын хамт 1836 оны дөрөвдүгээр сарын 3-нд Огайогийн Көртландын Ариун сүмд дахин хүрч ирж, Иосеф Смит Оливер Каудери хоёрт мөнхүү түлхүүрүүдийг олгожээ (С ба Г 110:13–16). Энэ бүхэн бол, Малахи 4:5–6-д өгүүлсэнчлэн, Их Эзэний Хоёр дахь Ирэлтийн бэлтгэл байлаа.

Елиагийн хүч бол дэлхий дээр түүгээр холбогддог буюу тайлагддаг зүйлүүд тэнгэрт мөн холбогддог буюу тайлагддаг тэрхүү санваарын хүчийг лацдах явдал мөн (С ба Г

128:8–18). Дэлхий дээр Их Эзэний сонгосон үйлчлэгчдэд лацдалтын энэ хүч байдаг бөгөөд тэд сайн мэдээний аврагч ёслолуудыг амьд байгаа хүмүүс болон нас барагсдын төлөө гүйцэтгэдэг (С ба Г 128:8).

Тэнгэрийг лацдаж, хэрээнүүдээр тэжээгдэв, **Хаад. дээд** 17:1–7. Бэлэвсэн эмэгтэй хул аяган дахь хоол, вааран дахь тосыг дуусгахгүй байхаар зарлигдуулав, **Хаад. дээд** 17:8–16. Бэлэвсэн эхнэрийн хүүг үхлээс босгов, **Хаад. дээд** 17:17–24. Баалын тахилчдыг сүйрүүлэв, **Хаад. дээд** 18:21–29. Намуун хүнгэнэх дуу хоолой түүнд яриу, **Хаад. дээд** 19:11–12. Галан тэргээр тэнгэрт дээшлэн одов, **Хаад. дэд** 2:11. Хожмын өдрүүдэд тэрээр эргэж ирэхийг Малахи бошиглов. **Малах.** 4:5–6 (3 Ниф. 25:5). 1836 онд Огайогийн Көртландын Ариун Сүмд үзэгдэв, **С ба Г** 110:13–16.

ЕЛИАС. Елиаг мөн үз

Сударт *Елиас* гэсэн нэр буюу цолыг хэд хэдэн янзаар хэрэглэдэг:

Өмнө нь ирэгч: Елиас бол өмнө нь гүйгч хүний нэр юм. Жишээ нь, Есүсийн замыг бэлтгэхээр илгээгдсэн учраас Иохан Баптист Елиас байв (Мат. 17:12–13).

Сэргээгч: Илчлэгч Иохан (С ба Г 77:14) түүнчлэн Габриел (Лук 1:11–20; С ба Г 27:6–7; 110:12) мэтчилэн онцгой ажил үүрэг гүйцэтгэдэг байсан бусад хүмүүст Елиас гэдэг нэрийг хамааруулдаг байжээ.

Абрахамын эрин үеийн хүн: Абрахамын өдрүүдэд амьдарч байсан нь тодорхой бошиглогчийг Есайас буюу Елиас хэмээн нэрлэдэг байв (С ба Г 84:11–13; 110:12).

ЕЛИЗАБЕТ. Иохан Баптистыг
мөн үз

Шинэ Гэрээнд Захариагийн эхнэр, Иохан Баптистын эх, тэрчлэн Мариагийн ойрын төрөл эмэгтэй (Лук 1:5–60).

ЕЛИША

Хуучин Гэрээн дэх Израилын Умард Хаант Улсын бошиглогч, мөн тэр улсын хэд хэдэн хааны итгэл хүлээсэн зөвлөх.

Елиша өөрийн эзэн Елиагийн бусдаас ялгардаг байсан хурц омголон араншингүй, эелдэг ялдам зантай байлаа. Түүний мэдэгдэхүйц гайхамшгууд нь (Хаад. дэд 2:5–8) тэрээр бошиглогч болж Елиаг залгамжлахдаа тэрээр Елиагийн хүчийг үнэхээр хүлээн авсныг нотолдог (Хаад. дэд 2:9–12). Жишээ нь гашуун булгийн усыг цэвэршүүлж, Иордан голын усыг хувааж, бэлэвсэн эмэгтэйн тосыг арвижуулж, нэг хөвгүүнийг нас барагсдаас босгон, уяман яртай хүнийг эдгээж, төмөр сүхийг хөвөх болгож, мөн сиричүүдийг сохор болгож байлаа (Хаад. дээд 2–6). Түүний тохинуулал Иерохам, Иеху, Иехоказ, мөн Иоаш нарын хаанчлалын үед тавь гаруй жил үргэлжилжээ.

Елиагийн нөмрөгийг авав, **Хаад. дэд 2:13**. Бэлэвсэн эмэгтэйн тосыг арвижуулав, **Хаад. дэд 4:1–7**. Шунем эмэгтэйн хүүг нас барагсдаас босгов, **Хаад. дэд 4:18–37**. Сири хүн, Нааманыг эдгээв, **Хаад. дэд 5:1–14**. Сирийн цэргүүдийг сохор болгож, харин өөрийн үйлчлэгчдийн нүдийг нээв, **Хаад. дэд 6:8–23**.

ЕЛОХИМ. Бурхан, Бурхан

Тэргүүтэн; Тэнгэр дэх Эцгийг
мөн үз

ЕМАНУЕЛ. Иммануелыг *мөн үз***ЕНОХ**. Сионыг *мөн үз*

Сионы хотын хүмүүсийг удирдаж байсан бошиглогч. Түүний тохинуулал Хуучин Гэрээ, Агуу Үнэт Сувд хоёуланд нь өгүүлэгддэг. Тэр бол Адамын дараа долоо дахь патриарх байв. Тэр бол Иаредын Хүү, Метуселагийн эцэг байв (Эхл. 5:18–24; Лук 3:37).

Енох бол агуу хүн байсан бөгөөд, Библид харуулсан түүний тухай товч

шастираас илүү чухал тохинуулал хийсэн билээ. Тэрээр зөөгдсөнийг (Евр. 11:5) Библи тэмдэглэсэн хэдий ч, түүний тохинууллын талаар нарийн ширийнийг өгүүлдэггүй байна. Иуда 1:14 нь түүний хийсэн бошиглолоос татсан ишлэлийг агуулдаг. Хожмын үеийн Илчлэлт нь Енохын тухай илүү ихийг, түүний номлол, Сион хэмээгддэг байсан түүний хотын тухай, түүний харсан үзэгдлүүд хийгээд бошиглолуудын тухай тусгайлан тайлбарласан байдаг (С ба Г 107: 48–57; Мосе 6–7). Үүнд амьдарч байсан хүмүүсийн зөв шударгын учир Сион тэнгэрт зөөгдөн аваачигджээ (Мосе 7:69).

Бурхан өөрийгөө Еноход илчлэв, **Мосе 6:26–37**. Енох сайн мэдээг зааж байв, **Мосе 6:37–68**. Енох хүмүүст зааж байв, мөн Сионыг үндэслэн байгуулав, **Мосе 7:1–21**. Енох Христийн Хоёр дахь ирэлтийн ирээдүйг харав, **Мосе 7:23–68**.

ЕРӨНХИЙЛӨГЧ. Бошиглогч;

Тэргүүн Зөвлөлийг *мөн үз*

Байгууллагыг тэргүүлдэг ажилтны албан нэр. Сүмийн Ерөнхийлөгч нь бошиглогч, үзмэрч, мөн илчлэгч байдаг (С ба Г 21:1; 107:91–92), түүнчлэн Сүмийн гишүүд Сүмийн бошиглогчийг Ерөнхийлөгч гэсэн албан нэрээр нь дуудах ёстой (С ба Г 107:65). Тэр бол санваарын бүх түлхүүрийг дэлхий дээр хэрэглэх эрх мэдэл бүхий цорын ганц хүн юм.

Санваартны чуулгууд болон Сүмийн бусад байгууллагуудын тэргүүнүүд нь түүнчлэн ерөнхийлөгчийн албан нэртэй байж болно.

Их Эзэн хаант улсын түлхүүрүүдийг Иосеф Смитэд өгөв, **С ба Г 81:1–2**. Гурван ерөнхийлөгч нь Сүмийн ерөнхийлөгчийн зөвлөлийн чуулгыг бүрдүүлдэг, **С ба Г 107:21–24**. Ерөнхийлөгчид нь Мелкизедекийн жаягийн дагуу томилогддог байв, **С ба Г 107:29**. Дикон, багш нар, санваартнууд хийгээд ахлагчдын талаарх ерөнхийлөгчдийн үүргүүд дүрслэг-

дэв, **С ба Г** 107:85–89 (С ба Г 124:136–38, 142). Бусад бүх Далын хувьд долоон ерөнхийлөгч буй, **С ба Г** 107:93–95. Гадаснуудын ерөнхийлөгчид томилогдсон байв, **С ба Г** 124:133–35.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ.

Тэргүүн Зөвлөлийг үз

ЕРӨНХИЙ ЭРХ МЭДЭЛТНҮҮД.

Дал; Төлөөлөгч; Тэргүүлэх бишоп; Тэргүүн Зөвлөлийг үз

ЕРӨӨЛҮҮД. Уулан дээрх

Номлолыг мөн үз

Уулан дээрх Номлолд Есүсийн өгсөн сайжруулсан мөн сүнслэг зан чанаруудыг дүрсэлсэн хэд хэдэн сургаал багтдаг (Мат. 5:3–12; Лук 6:20–23). Ерөөлүүд нь өмнөх хэлсэн зүйлийнхээ дээр суурилсан байдаг. Ерөөлүүдийн илүү ойлгомжтой мөн зөв цэдгийг 3 Нифай 12-оос үзэж болно.

ЕСАВ. Исаак; Исаакийн хүү

Иаковыг мөн үз

Хуучин Гэрээнд, Исаак Ребека хоёрын ууган хүү, Иаковын ихэр ах. Ах дүү хоёр бүр төрснөөсөө эхлэн өрсөлдөгчид байв (Эхл. 25:19–26). Есавын үр удмынхан едомчууд, түүнчлэн Иаковын удмынхан израилчууд гэсэн өрсөлдөгч үндэстнүүд болжээ (Эхл. 25:23).

Есав залгамжлах эрхээ Иаковт худалдав, **Эхл.** 25:33 (Евр. 12:16–17). Есав эцэг эхээ уй гашуу болоход хүргэж, хит эхнэрүүдтэй гэрлэв, **Эхл.** 26:34–35. Иаков Есав хоёр эвлэрэв, **Эхл.** 33.

ЕСАИАС

Исаиагийн нэрний Шинэ Гэрээний (грек) хэлбэр (Лук 4:17). Есаиас бол бас Абрахамын өдрүүдэд амьдарч байсан бошиглогч байв (С ба Г 76:100; 84:11).

ЕСТЕР

Агуу итгэл бүхий эмэгтэй мөн Естерийн номын гол баатар.

Естерийн ном: Өөрийн хүмүүсийг устгалаас аврахад агуу их зориг гаргасан Хатан Хаан Естерийн түүхийг агуулдаг, Хуучин Гэрээний нэг ном.

Бүлэг 1–2 нь Мордекай хэмээх нэртэй иудей хүнээс өргөж авсан охин, иудей эмэгтэй Естер гоо үзэсгэлэнгийнхээ улмаас Персийн хатан хаанаар хэрхэн сонгогдсоныг өгүүлдэг. Бүлэг 3 нь хааны шүүхийн гол хүн Хаман Мордекайг үзэн яддаг байсан хийгээд бүх иудей хүмүүсийг үхэлд хүргэх тогтоол гаргуулсныг тайлбарладаг. Бүлэг 4–10 нь Естер хувь хүнийхээ хувьд ихэд аз туршин, өөрийн яс үндсээ хаанд илчилж, дээрх тогтоолыг хүчингүй болгуулжээ.

ЕСҮС ХРИСТ. Аврагч; Адам Ева

хоёрын Уналт; Альфа ба Омега; Амилуулалт; Амьд ус; Амьдралын талх; Ариун ёслол; Ач ивээл; БИ БАЙДАГ; Булангийн тулгуур чулуу; Бурхан; Бурхан Тэргүүтэн; Бурханы Хурга; Бүтээлт, Бүтээх; Голгота; Гуулин могой; Гэрэл; Гэтэлгэгдэгсэд; Гэтэлгэгч; Гэтэлгэл; Гэтэлгэлийн төлөвлөгөө; Гэтэлгэх; Есүс Христийн Хоёр дахь Ирэлт; Загалмай; Зам; Золиослол; Зууч; Иехова; Иммануел; Итгэл; Их Эзэн; Мариа, Есүсийн Эх; Мессиа; Наманчлал; Наманчлах; Нүглүүдээс ангижрах; Өмгөөлөгч; Сайн Мэдээнүүд; Сайн Хоньчин; Тайтгаруулагч; Тослогдсон Нэгэн; Төгсгөлгүй; Төрсөн; Тэнгэрт Дээшлэн одох; Ууган Хүү; Уулан дээрх Номлол; Ухамсар; Хад; Христийн гэрэл; Хувиралт—Христийн Хувиралт; Хүний Хүү; Хүргэн Хүү; Цагаатгал; Цагаатгах; Цовдлолт; Цус; Чөлөөлөгч; Эхлэлийг мөн үз

Христ (грек үг) түүнчлэн Мессиа (еврей үг) нь адислагдсан гэсэн утгатай. Есүс Христ бол сүнсэнд төрсөн, Эцэгийн Ууган Хүү билээ (Евр. 1:6; С ба Г 93:21). Тэр бол махан биед

төрсөн, Эцэгийн Төрсөн Ганц мөн (Иохан 1:14; 3:16). Тэр бол Иехова (С ба Г 110:3–4) бөгөөд дэлхий бүтээгдэхээс өмнө өөрийн агуу дуудлагад томилогдсон байв. Есүс, Эцэгийн удирдлаган дор дэлхий болон үүн дээрх бүх зүйлийг бүтээжээ (Иохан 1:3; 14; Мосе 1:31–33). Тэрээр Бетлехемд Мариагаас төрж, нүгэлгүй амьдралаар амьдарч байв, мөн өөрийн цусыг урсгаж, загалмай дээр амь насаа өгснөөр бүх хүн төрөлхтний нүглийн төлөө төгс цагаатгал хийсэн юм (Мат. 2:1; 1 Ниф. 11:13–33; 3 Ниф. 27:13–16; С ба Г 76:40–42). Тэрээр нас барагсдаас босч, тийнхүү бүх хүн төрөлхтний зайлшгүй амилуулалтыг баталгаатай болгосон юм. Нүглүүдээ наманчилдаг болон Бурханы зарлигуудыг дуулгавартай дагадаг хүмүүс Есүсийн цагаатгал хийгээд амилалтаар дамжин, Есүс болон Эцэгтэй хамт үүрд мөнхөд амьдарч чадна (2 Ниф. 9:10–12; 21–22; С ба Г 76:50–53, 62).

Есүс Христ бол энэ дэлхий дээр төрсөн хамгийн агуу хүн юм. Түүний амьдрал бол бүх хүмүүн төрөлхтөн хэрхэн амьдрах ёстойн төгс үлгэр жишээ мөн. Бүх залбирлууд, адислалууд хийгээд санваарын ёслолууд түүний нэрээр хийгдэх ёстой. Тэр бол Эздийн Их Эзэн, Хаадын Хаан, Бүтээгч, Аврагч, мөн бүх дэлхийн Бурхан билээ.

Мянганы үед Есүс Христ дэлхий дээр хаанчлахаар сүр хүч хийгээд алдар суунд дахин ирэх болно. Эцсийн өдөр тэрбээр бүх хүн төрөлхтнийг шүүх болно (Алма 11:40–41; ИС—Мат. 1).

Түүний амьдралын хураангуй (үйл явдлуудын дарааллаар): Есүсийн төрөлт хийгээд үүрэг угтан хэлэгдсэн байв, **Лук** 1:26–38 (Иса. 7:14; 9:6–7; 1 Ниф. 11). Төрөв, **Лук** 2:1–7 (Мат. 1:18–25). Хөвч хөндүүлэв, **Лук** 2:21. Ариун сүмд танилцуулагдав, **Лук** 2:22–38. Мэргэн хүмүүс ирж уулзав, **Мат.** 2:1–12. Иосеф Мариа хоёр түүнтэй хамт Египет уруу зугтав, **Мат.** 2:13–18. Назарт авчрагдав, **Мат.**

2:19–23. Арванхоёр настайдаа ариун сүмд очив, **Лук** 2:41–50. Эрэгтэй, эмэгтэй дүү нартай болов, **Мат.** 13:55–56 (Марк 6:3). Баптисм хүртэв, **Мат.** 3:13–17 (Марк 1:9–11; Лук 3:21–22). Чөтгөрөөр соригдов, **Мат.** 4:1–11 (Марк 1:12–13; Лук 4:1–13). Шавь нараа дуудав, **Мат.** 4:18–22 (Мат. 9:9; Марк 1:16–20; 2:13–14; Лук 5:1–11; 27–28; 6:12–16; Иохан 1:35–51). Арванхоёрт итгэмжлэл хүлээлгэв, **Мат.** 10:1–4 (Марк 3:13–19; Лук 6:12–16). Уулан дээр Номлол айлдав, **Мат.** 5–7. Өөрийн хэл хийгээд амилалтыг угтан хэлэв, **Мат.** 16:21 (Мат. 17:22–23; 20:17–19; Марк 8:31; 9:30–32; 10:32–34; Лук 9:22; 18:31–34). Хувирав, **Мат.** 17:1–9 (Марк 9:2–8; Лук 9:28–36). Далыг илгээв, **Лук** 10:1–20. Иерусалимд ялгуусан байдлаар оров, **Мат.** 21:1–11 (Марк 11:1–11; Лук 19:29–40; Иохан 12:12–15). Ариун ёслолыг бий болгов, **Мат.** 26:26–29 (Марк 14:22–25; Лук 22:19–20). Гетсеманид зовж, мөн залбирав, **Мат.** 26:36–46 (Марк 14:32–42; Лук 22:39–46). Түүнээс урваж, баривчлагдан, мөн хаягдав, **Мат.** 26:47–56 (Марк 14:43–53; Лук 22:47–54; Иохан 18:2–13). Цовдлогдов, **Мат.** 27:31–54 (Марк 15:20–41; Лук 23:26–28, 32–49; Иохан 19:16–30). Амилав, **Мат.** 28:1–8 (Марк 16:1–8; Лук 24:1–12; Иохан 20:1–10). Амилалтынхаа дараа хүрч ирэв, **Мат.** 28:9–20 (Марк 16:9–18; Лук 24:13–48; Иохан 20:11–31; Үйлс 1:3–8; 1 Кор. 15:5–8). Тэнгэрт дээшлэв, **Марк** 16:19–20 (Лук 24:51–53; Үйлс 1:9–12). Нифайчууд дээр хүрч ирэв, **3 Ниф.** 11:1–17 (3 Ниф. 11–26). Иосеф Смит дээр хүрч ирэв **ИС—Т** 1:15–20.

Есүс Христийн төрөлт хийгээд хөнөөгдөх тухай бошиглолууд: Нэгэн онгон бүсгүй жирэмсэлж хүүтэй болно, **Иса.** 7:14 (1 Ниф. 11:13–20). Израилын захирагч Бетлехемээс гарч ирэх болно, **Мика** 5:2. Лемен үндэстэн Самуел нэг өдөр нэг шөнө мөн гэрэлтэй өдрийг; мөн нэг шинэ одыг; түүнчлэн бусад тэмдгүүдийг бошиглов, **Хил.** 14:2–6. Лемен үндэстэн Самуел харанхуй, аянга, мөн

цахилгаан, дэлхийн чичрэлтийг бо-
шиглов, **Хил.** 14:20–27. Есүсийн тө-
рөлтийн тэмдгүүд биелэгдэв, **3 Ниф.**
1:15–21. Есүсийн хөнөөгдөлтийн
тэмдгүүд биелэгдэв, **3 Ниф.** 8:5–23.

Христийн мянган жилийн хаанчлал:
Засаглал түүний мөрөн дээр байх
болно, **Иса.** 9:6 (2 Ниф. 19:6). Би та
нарын дунд оршин суух болно хэ-
мээн Эзэн айлдав, **Зех.** 2:10–12 (Зех.
14:9). Эцэг Давидынх нь хаан сэнтийг
Бурхан Есүс Христэд өгөх болно, **Лук**
1:30–33. Христ үүрд мөн мөнхөд
хаанчлах болно, **Илч.** 11:15. Гэгээнт-
нүүд Христтэй хамт мянган жил
хаанчлах болно, **Илч.** 20:4 (С ба Г
76:63). Хүмүүсийн зөв шударгын
улмаас Сатан хүчгүй байх болно,
1 Ниф. 22:26 (Илч. 20:1–3). Бибээр
дэлхий дээр хүмүүстэй хамт зөв
шударга байдалд мянган жил ор-
шин суух болно, **С ба Г** 29:11 (С ба Г
43:29–30). Эрх нь хаанчлал болох
түүнийг хаанчлах хүртэл С захих хүч-
нүүдэд захирагдагтун, **Ег.** 58:22
(1 Кор. 15:25). Христ дэлхий дээр өө-
рийн биеэр хаанчлах болно, **ИТ** 1:10
(Иса. 32:1).

Христийн бэлэгдлийн хэлбэрүүд: Абел
сүргийнхээ ууган толүүдийг өргө-
жээ, **Эхл.** 4:4 (Моце 5:20). Чи цорын
ганц хүү Исаакаа авч, түүнийг тахил
болгон өргө, **Эхл.** 22:1–13 (Иаков
4:5). Гэм согоггүй хургуудаар тахил
өргөж байхыг Эзэн Израилын хүүх-
дүүдэд зарлиглажээ, **Ег.** 12:5, 21, 46
(Тоол. 9:12; Иохан 1:29; 19:33; 1 Петр
1:19; Илч. 5:6). Энэ бол ид хэмээн та
нарт Эзэний өгсөн талх, **Ег.** 16:2–15
(Иохан 6:51). Хадыг цохь, тэгвэл
тэндээс ус гарч ард түмэн уух бол-
но, **Ег.** 17:6 (Иохан 4:6–14; 1 Кор.
10:1–4). Ухна тэдний бүх алдсыг өөр
дээрээ авч явах болно, **Лев.** 16:20–22
(Иса. 53:11; Моз. 14:11; 15:6–9). Гуу-
лин могойг харж байсан хүмүүсийг
аврахын тулд Моце үүнийг өргөв,
Тоол. 21:8–9 (Иохан 3:14–15; Алма
33:19; Хил. 8:14–15). Иона загасны
гэдсэнд гурван өдөр байв, **Иона** 1:17
(Мат. 12:40). Энэ зүйл бол Эцэгийн

Төрсөн Ганцын золиослолтой адил
төстэй юм, **Моце** 5:4–8.

Шүүгч: Тэрээр дэлхийг зөв шударга
байдалд шүүх болно, **Дуул.** 9:8
(3 Ниф. 27:16). Тэрээр дэлхийг шүү-
хээр ирнэ, **Дуул.** 96:13. Шударга
хүн ба гэм нүгэлтний аль алиныг нь
Бурхан шүүнэ, **Номл.** үгс 3:17. Тэр
үндэстнүүдийн дунд шүүх болно,
Иса. 2:4 (Мика 4:3; 2 Ниф. 12:4). Тэр
ядуусыг зөв шударгаар шүүх бол-
но, **Иса.** 11:2–4. Эцэг бүх шүүлтийг
Хүүд даатгав, **Иохан** 5:22. Хэрвээ би
шүүвэл, миний шүүлт үнэн байна,
Иохан 8:16. Тэр бол Бурханаар то-
милогдсон амьд, үхсэн бүх хүний
шүүгч мөн, **Үйлс** 10:42 (2 Тим. 4:1).
Бурхан хүмүүсийн нууц зүйлсийг
Есүс Христээр шүүх болно, **Ром**
2:16. Бид бүгдээрээ Христийн шүүх
ширээний өмнө зогсох болно, **Ром**
14:10 (2 Кор. 5:10; Алма 12:12; Морм.
3:20; 7:6; Ифер 12:38; С ба Г 135:5).
Түүнд байдаг үнэн хийгээд ариун
байдлын дагуу түүгээр шүүгдэхийн
тулд бүх хүмүүн Бурханд ирдэг бөл-
гөө, **2 Ниф.** 2:10. Үйлүүдийнхээ дагуу
шүүгдэхээр Бурханы өмнө зогсог-
тун, **Алма** 5:15 (Алма 12:15; 33:22;
3 Ниф. 27:14). Бурхан Христ хоёр
бол бүхний шүүгч мөн, **С ба Г** 76:68.

*Есүс Христийн нэрийг бид өөрсөд дээ-
рээ авах нь:* Бидний аврагдах ёстой
өөр нэр үгүй, **Үйлс** 4:12 (2 Ниф.
31:21). Түүний нэрнээс болж зово-
хоор тийм зохистой тооцогдсондоо
Төлөөлөгчид баярлацгаав, **Үйлс**
5:38–42. Бид Түүний Хүү Есүс Хрис-
тийн нэрэнд итгэх нь түүний зар-
лиг бөлгөө, **1 Иохан** 3:23. Та нар бап-
тисмаар Христийн нэрийг өөрсөд
дээрээ авахад бэлэн байгаагаа гэрч-
лэгтүн, **2 Ниф.** 31:13. Та нар Хрис-
тийн нэрийг өөрсөд дээрээ аваасай
хэмээн хүснэ би, **Моз.** 5:6–12 (Моз.
1:11). Өөрсөд дээрээ Христийн нэ-
рийг авах хүсэлтэй байсан хэн бо-
ловч Бурханы Сүмд нэгдсэн болой,
Моз. 25:23. Христэд жинхэнэ итгэг-
чид байсан тэд бүгд Христийн нэ-
рийг өөрсөд дээрээ авав, **Алма** 46:15.

Есүс Христийн нэрэнд итгэх тэдэнд тэнгэрийн хаалга нээлттэй байдаг, **Хил.** 3:28. Эцсийн өдөр миний нэрэнд итгэлтэй хэвээр байх тэрээр адислагдсан болой, **Ифер** 4:19. Тэд Хүүгийн нэрийг өөрсөд дээрээ авахад бэлэн байдаг, **Моро.** 4:3 (С ба Г 20:77). Христийн нэрийг өөрсөд дээрээ авагтун, **С ба Г** 18:21–25.

Мөнх бус байдлын өмнө Христ оршиж байсан нь: Эзэн Абрамд үзэгдэв, **Эхл.** 12:7 (Эхл. 17:1; 18:1; Абр. 2:6–8). Эзэн Мосетой нүүр нүүрээрээ тулан ярьдаг байв, **Ег.** 33:11 (Дэд хууль 34:10; Мосе 1:1–2). Тахилын ширээний хажууд зогсч буй Эзэнийг би харсан, **Амос** 9:1. Эхэнд үг Бурхантай хамт байв. Мөн Үг нь махан бодийг бий болгож, мөн бидний дунд оршиж байв, **Иохан** 1:1; 14 (1 Иохан 1:1–3). Абрахамын өмнө би байдаг байсан, **Иохан** 8:58. Ертөнцийг бүтээхээс өмнө тантай хамт надад байсан сүүр жавхлангаар намайг Та өөрийнхөө хамт алдаршуулаач, **Иохан** 17:5. Би болон миний ах Иаков түүнийг харсны адилаар Исаиа үнэхээр миний Гэтэлгэгчийг харжээ, **2 Ниф.** 11:2–3. Маргааш би дэлхийд ирэх бөлгөө, **3 Ниф.** 1:12–14. Дэлхийн эхлэлээс өмнө Христ байсан, **3 Ниф.** 26:5 (Иохан 6:62). Би чам дээр хүрч ирсний адилаар би өөрийн хүмүүс дээр махан бодид хүрч ирэх болно, **Ифер** 3:14–17. Енох Их Эзэнийг харж мөн түүнтэй хамт алхаж явав, **С ба Г** 107:48–49. Миний Хайрт Хүү мөн эхлэлээс Сонгогдсон Хайрт минь, **Мосе** 4:2. Их Эзэн хэлэв: Хэнийг илгээх билээ би? Хүний Хүүтэй адил нэгэн хариулав: Би энд байна, намайг илгээгтүн, **Абр.** 3:27.

Сүмийн тэргүүн: Христ бол Сүмийн тэргүүн, **Еф.** 5:23 (Еф. 1:22; 4:15). Тэр бол байгууллага, Сүмийн тэргүүн мөн, **Кол.** 1:18. Энэ бол миний Сүм, **Моз.** 26:22 (Моз. 27:13). Христ тэдний итгэлийн зохиогч мөн дуусгагч байв, **Моро.** 6:1–4. Энэ Сүмийг би үндэслэн байгууллаач, **С ба Г** 33:5 (3 Ниф. 27:3–8).

Есүс Христийн тухай гэрчлэл: Есүс бол Христ гэдгийг Паул гэрчлэв, **Үйлс** 18:5. Бүр бузар сүнснүүд хүртэл тэд Есүсийг танина хэмээн гэрчлэв, **Үйлс** 19:15. Ариун Сүнсээр бус бол Есүс бол Эзэн хэмээн хэн ч хэлж эс чадна, **1 Кор.** 12:3. Өвдөг бүхэн сөхөрч мөн хэл болгон Есүс Христ бол Эзэн хэмээн хүлээн зөвшөөрөх болно, **Филип** 2:10–11. Бид Христийн тухай ярьдаг, бид Христэд баясдаг, бид Христийн талаар номлодог, бид Христийн тухай бошиглодог, **2 Ниф.** 25:26. Мормоны Ном бол Есүс бол Христ мөн гэдгийг Иудей хийгээд Харьд итгүүлэх явдал болой, **2 Ниф.** 26:12 (Мормоны Номын оршил хуудас). Бошиглогчид хийгээд судрууд Христийн тухай гэрчилдэг, **Иаков** 7:11, 19. Бошиглогчид хийгээд төлөөлөгчдийн тухайлан бичсэн энэхүү Есүсийг эрэлхийлэгтүн, **Ифер** 12:41. Бид түүнийг харж, мөн тэр бол Төрсөн Ганц хэмээн гэрчлэх дуу хоолойг сонсов, **С ба Г** 76:20–24. Бурхан хийгээд Есүс Христийг мэдэх нь, энэ нь мөнх амьдрал мөн, **С ба Г** 132:24. Мөнхийн Эцэг, Бурхан, Түүний Хүү, Есүс Христэд бид итгэдэг, **ИТ** 1:1. Христ дэлхий дээр өөрийн биеэр хаанчилна гэдэгт бид итгэдэг, **ИТ** 1:10.

Эрх мэдэл: Засаглал түүний мөрөн дээр байх болно, **Иса.** 9:6 (2 Ниф. 19:6). Есүс эрх мэдэлтэй нэгэний адилаар зааж байлаа, **Мат.** 7:28–29 (Марк 1:22). Хүний Хүү газар дээр нүглийг уучлах эрх мэдэлтэй, **Мат.** 9:6. Есүс эрх мэдэлтэйгээр бузар сүнснүүдэд тушаахад тэд түүнийг дуулавартай дагаж байлаа, **Марк** 1:27 (Лук 4:33–36). Есүс арванхоёрыг тэдэнд хүч байхын тулд томиллов, **Марк** 3:14–15. Есүсийн үг эрх мэдэлтэй байв, **Лук** 4:32. Эцэг бүх шүүлтийг Хүүд даатгав, **Иохан** 5:22–27. Есүсийг Бурхан Ариун Сүнс хийгээд эрх мэдлээр адислав, **Үйлс** 10:38. Христ ертөнцийн суурианаас өмнө урьдчилан томилогдсон байв, **1 Петр** 1:20 (Ифер 3:14). Тамын болон

үхлийн түлхүүрүүд Христэд бий, **Илч.** 1:18. Бүх хүмүүн Христэд захирагдсан байна, **2 Ниф.** 9:5. Бурханы Хүү Есүс Христ бол тэнгэр ба газрын Эцэг, эхлэлээс бүх зүйлүүдийн Бүтээгч билээ, **Хил.** 14:12. Эцэгийн тааллаар, түүний тааллыг гүйцэлдүүлэхээр Христ ирсэн, **С ба Г** 19:24. Эцэгийн бүрэн алдар сууг Христ хүлээж авсан; тэрээр бүх эрх мэдэл, хүчийг хүлээн авсан юм, **С ба Г** 93:3–4, 16–17 (Иоан 3:35–36).

Мөнх бус байдлын дараа Христ хүрч ирсэн нь: Есүс босч ирээд, тэрээр Марид анх үзэгджээ, **Марк** 16:9 (Иоан 20:11–18). Есүс явган явж мөн Еммау уруу явсан зам дээр хоёр шавьтайгаа ярилцаж байв, **Лук** 24:13–34. Есүс Төлөөлөгчид дээр хүрч ирээд тэд гар хөлийг нь барьж үзэв, **Лук** 24:36–43 (Иоан 20:19–20). Есүс Томас дээр хүрч ирэв, **Иоан** 20:24–29. Тиберт нуурын дэргэд Есүс шавь нар дээрээ хүрч ирэв, **Иоан** 21:1–14. Есүс амилалтынхаа дараа дөчин өдрийн турш тохинуулав, **Үйлс** 1:2–3. Есүс Бурханы баруун гар талд зогсч байхыг Стефен харав, **Үйлс** 7:55–56. Есүс Саулд үзэгдэв, **Үйлс** 9:1–8 (ИСО, **Үйлс** 9:7; **Үйлс** 26:9–17). Христ 500 гаруй хүмүүст харагдсан байлаа, **1 Кор.** 15:3–8. Есүс Христ Нифайн хүмүүст өөрийгөө харуулав, **3 Ниф.** 11:1–17. Есүсийг 2500 хүн харж мөн сонсов, **3 Ниф.** 17:16–25. Мормон Их Эзэнээр зочлогдов, **Морм.** 1:15. Иосеф Смит, Сидней Ригдон хоёр Есүсийг Бурханы баруун гар талд харав, **С ба Г** 76:22–23. Иосеф Смит, Оливер Каудери хоёр Кортландын Ариун Сүмд Их Эзэнийг харав, **С ба Г** 110:1–4. Иосеф Смит Есүсийг харав, **ИС—Т** 1:15–17.

Есүс Христийн үлгэр жишээ: Би та нарт үлгэр жишээ үзүүллээ, **Иоан** 13:15. Би бол зам, үнэн, мөн амьдрал билээ, **Иоан** 14:6. Та нарыг өөрийнхөө мөрөөр дагуулахын тулд Христ тэрчлэн бидний төлөө зовлон эдэлж, бидэнд үлгэр дууриал үлдээсэн билээ, **1 Петр** 2:21. Хэрэв хүн амьд

Бурханы Хүүгийн үлгэр жишээг эс дагах аваас, тэрээр аврагдаж чадахгүй, **2 Ниф.** 31:16. Бүр миний адилаар та нарыг төгс байгаасай хэмээнэ би, **3 Ниф.** 12:48. Үүнийг та нар, бүр яг миний хийсэн шигээр хийхээр үргэлж чармайх болно, **3 Ниф.** 18:16. Би та нарт үлгэр жишээ үзүүллээ, **3 Ниф.** 18:16. Миний хийхийг өөрсдөө харсан тэр ажлуудыг та нар түүнчлэн хийх болно, **3 Ниф.** 27:21, 27. Есүс Христийн жинхэнэ дагалдагчид түүнтэй адилхан байх болно, **Моро.** 7:48.

Есүс Христийн алдар суу: Эзэний алдар асрыг дүүргэв, **Ег.** 40:34–38. Бүх л газар түүний алдраар дүүрэн байг, **Иса.** 6:3 (2 Ниф. 16:3). Эзэний цог жавхлан чиний дээр мандаж байна, **Иса.** 60:1–2. Хүний Хүү Эцэгийнхээ алдар сууд ирэх болно, **Мат.** 16:27. Ертөнцийг бүтээхээс өмнө тантай хамт надад байсан сүр жавхлангаар Та намайг Өөрийнхөө хамт алдаршуулаач, **Иоан** 17:5. Израилын Ариун Нэгэн агуу их алдар суугаар хаанчлах ёстой, **1 Ниф.** 22:24. Түүний сүр жавхланг хүлээн авах найдлага бидэнд байв, **Иаков** 4:4. Бурханы Хүү өөрийн алдар суунд ирэх бөлгөө, **Алма** 5:50. Бүх эхлэлээс тэрбээр өөрийн алдар сууд ирэх хүртэлх бүх зүйлийг тайлбарлав, **3 Ниф.** 26:3. Миний Төлөөлөгчид бүр миний адилаар алдар суунд хувцаслагдан зогсч байх болно, **С ба Г** 29:12 (С ба Г 45:44). Эцэгийн баруун гар тал дахь Хүүгийн алдар сууг бид болгоов, **С ба Г** 76:19–23. Иоан миний алдар суугийн бүрэн байдлыг харж мөн гэрчилсэн билээ, **С ба Г** 93:6 (Иоан 1:14). Түүний төрх байдал нарны гэрлээс илүү хурц байв, **С ба Г** 110:3. Түүний алдар суу над дээр байж, мөн бибээр түүний нүүрийг болгоов, **Моце** 1:1–11. Энэ бол миний ажил мөн миний алдар суу бөлгөө, **Моце** 1:39.

ЕСҮС ХРИСТИЙН СҮМ. Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс; Гэгээнтэн; Есүс Христийн

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүм; Сайн Мэдээний сэргээлт;
Сүмийн нэр; Үнэн Сүмийн
тэмдгүүдийг *мөн үз*

Баптисм болон гишүүний баталгаагаар Есүс Христийн нэрийг өөр дээрээ авсан итгэгчдийн зохион байгуулагдсан байгууллага. Үнэн Сүм байхын тулд энэ нь Их Эзэний Сүм байх; түүний эрх мэдэл, сургаалууд, хуулиуд, ёслолууд мөн нэртэй байх шаардлагатай бөгөөд түүний томилсон төлөөлөгчдөөр дамжуулан түүгээр удирдуулах ёстой.

Их Эзэн Сүм дээр өдрөөс өдөрт нэмдэг, **Үйлс** 2:47. Бид олуулаа Христ дотор нэгэн бие болой, **Ром** 12:5. Нэг Сүнсээр нэг бие уруу баптисм хүртсэн билээ, **1 Кор** 12:13. Сүм Төлөөлөгчид болон бошиглогчдын суурин дээр баригддаг, **Ефес** 2:19–20. Сүмд Төлөөлөгчид болон бошиглогчид гол үндэс нь юм, **Ефес** 4:11–16. Христ бол Сүмийн тэргүүн юм, **Ефес** 5:23. Тийнхүү тэнд олон сүм байсан хэдий ч, тэд бүгд нэг сүм байв, **Моз.** 25:19–22. Сүм цэвэршигдэж мөн эмх журамд орсон байв, **Алма** 6:1–6. Христийн Сүм түүний нэрээр нэрлэгдэх ёстой, **3 Ниф.** 27:8. Сүмийнхэн мацаг барихаар мөн залбирахаар, мөн ярихаар ойр ойрхон цугладаг байв, **Моро.** 6:5. Энэ бол цорын ганц үнэн бөгөөд амьд Сүм юм, **С ба Г** 1:30. Христийн Сүм энэ эцсийн өдрүүдэд өсөн нэмэгдэв, **С ба Г** 20:1. Их Эзэн үйлчлэгчдээ өөрийн Сүмийг байгуулахын тулд дууддаг, **С ба Г** 39:13. Учир нь миний Сүм эцсийн өдөр ийн нэрлэгдэх болно, **С ба Г** 115:4.

**ЕСҮС ХРИСТИЙН ТӨРӨЛТ
ХИЙГЭЭД ХӨНӨӨГ ДӨЛТИЙН
ТЭМДГҮҮД.** Есүс Христийг
мөн үз

Есүс Христийн төрөлт хийгээд хөнөөгдөлттэй дагалдах үйл явдлууд.

Төрөлт: Онгон бүсгүй хүүхэдтэй болж хүү төрүүлнэ, **Иса.** 7:14. Бетлехемээс Израилын захирагч гарч ирэх

болно, **Мика** 5:2. Лемен үндэстэн Самуел өдөр, шөнө, мөн өдрийн гэрэл; шинэ од; болон бусад тэмдгүүдийг бошиггосон бөлгөө, **Хил.** 14:2–6. Тэмдгүүд биелэгдэв, **3 Ниф.** 1:15–21.

Хөнөөгдөлт: Лемен үндэстэн Самуел харанхуй, тэнгэрийн дуу, мөн гялбаа хийгээд газар хөдлөлтийн тухай бошиглов, **Хил.** 14:20–27. Тэмдгүүд биелэгдэв, **3 Ниф.** 8:5–23.

**ЕСҮС ХРИСТИЙН ХОЁР ДАХЬ
ИРЭЛТ.** Армагеддон; Гог; Есүс
Христ; Магог; Цаг хугацааны
тэмдгүүдийг *мөн үз*

Мянган жилийн эрин үеийн эхэнд Христ дэлхийд эргэж ирнэ. Энэ үйл явдал нь дэлхийн мөнх бус сорилтын төгсгөл болон цэдэглэгдэнэ. Дэлхий цэвэршигдэх үед ёс бусыг үйлдэгчид дэлхийгээс зайлуулагдаж мөн зөв шударгыг үйлдэгчид үүлэн дунд аваачигдана. Хэдийгээр Христ хоёр дахь удаагаа хэзээ ирэхийг хэн ч мэдэхгүй ч, уг хугацаа ойртож буйг харуулах тэмдгүүдийг тэрээр бидэнд өгсөн билээ (**Мат.** 24; **ИС—М** 1).

Миний Гэтэлгэгч хожмын өдөр дэлхий дээр зогсохыг би мэднэ, **Иов** 19:25. Надад өвдөг бүхэн сөхөрч, хэл бүр амлах болно, **Иса.** 45:23 (**С ба Г** 88:104). Хүний Хүү тэнгэрийн үүлнүүдтэй хамт ирнэ, **Дан.** 7:13 (**Мат.** 26:64; **Лук** 21:25–28). Өөрсдөө жадалсан намайг тэд харна, **Зех.** 12:10. Нэг нь таны гарт буй эдгээр шархнууд юу вэ хэмээн хэлэх болно, **Зех.** 13:6 (**С ба Г** 45:51). Түүний ирэх өдрийг хэн тэсвэрлэж чадах вэ? Учир нь тэрээр цэвэршүүлэгчийн гал лугаа адил юм, **Малах.** 3:2 (**3 Ниф.** 24:2; **С ба Г** 128:24). Хүний Хүү Эцэгийнхээ алдар сууд ирэх болно, **Мат.** 16:27 (**Мат.** 25:31). Тэр өдөр хийгээд цагийг миний Эцэгээс өөр хэн ч үл мэднэ, **Мат.** 24:36 (**С ба Г** 49:7; **ИС—Мат.** 1:38–48). Энэхүү Есүс та нар Түүнийг тэнгэр өөд явсныг харсны адил тийн буцаж ирнэ, **Үйлс** 1:11. Их Эзэн өөрөө тэнгэрээс бууж ирнэ, **1 Тес.** 4:16. Их Эзэний өдөр нь шөнийн хулгайч

адил ирэх болно, **2 Петр** 3:10. Их Эзэн өөрийн арван мянган Гэгээнтэнтэйгээ хамт ирнэ, **Шүүгч**. 1:14. Тэрээр үүлэнд ирнэ; мөн нүд бүхэн түүнийг харах болно, **Илч**. 1:7. Есүс дэлхийг шүүхээр зогсоно, **3 Ниф**. 27:14–18. Бэлтгэгцээ, та нар, бэлтгэгцээ, та нар, учир нь Их Эзэн ойрхон байна, **С ба Г** 1:12. Бибээр өөрийгөө тэнгэрээс хүчтэйгээр илрүүлэх болно, мөн дэлхий дээр мянган жил амьдрах болно, **С ба Г** 29:9–12. Дуу хоолойгоо өргөн мөн наманчлалыг хашгиран түүний хоёр дахь ирэлтийн тулд Их Эзэний замыг бэлтгэ, **С ба Г** 34:5–12. Бибээр Есүс Христ, мөн би ариун сүмдээ гэнэт ирнэ, **С ба Г** 36:8 (**С ба Г** 133:2). Намайг харах хийгээд бибээр мөн гэдгийг мэдэх өдөр удахгүй ирнэ, **С ба Г** 38:8. Надаас эмээгч тэр нь Хүний Хүүгийн ирэлтийн тэмдгүүдийг хайх болно, **С ба Г** 45:39. Их Эзэний нүүр илрүүлэгдэх болно, **С ба Г** 88:95. Их Эзэний агуу хийгээд аймшигт өдөр ойрхон байна, **С ба Г** 110:16. Аврагч залран ирэхэд бид түүнийг байгаагаар нь харах болно, **С ба Г** 130:1. Аврагч хүмүүсийнхээ дунд зогсож мөн хаанчлах болно, **С ба Г** 133:25. Тэнгэр дэх Бурханаас доош буун ирэгч, будсан өмсгөлтэй энэ чинь хэн бэ? **С ба Г** 133:46 (**Иса**. 63:1).

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ. Есүс Христийн Сүм; Сайн Мэдээний сэргээлт; Сүмийн нэр; Үнэн Сүмийн тэмдгүүдийг мөн үз

Бусад эрин үеүдийн Сүмээс ялгахын тулд хожмын өдрүүд дэх Есүс Христийн Сүмд өгсөн нэр (**С ба Г** 115:3–4).

Их Эзэн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн тэргүүн дээр мэдлэгийг юүлэх болно, **С ба Г** 121:33. Иосеф Смит бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн бошиглогч мөн үзмэрч юм, **С ба Г** 127:12. Их Эзэний агуу их өдөр Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн гарт байна, **С ба Г** 128:21, 24. Смит Хожмын

Үеийн Гэгээнтнүүдийг цуглуулахад Иосеф Смит туслан, **С ба Г** 135:3. Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хамтлагууд Нэгдсэн Улсын өрнөд нутаг уруу аялалд зохион байгуулагдах ёстой, **С ба Г** 136:2. Гэрлэлтийн хуулиуд Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд ойлгомжтой болов, **С ба Г** АТ—1. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн бүх зохистой эрэгтэй гишүүдэд санваар өгөгдөв, **С ба Г** АТ—2. Анхны Үзэгдлийн шастир Хожмын Үеийн бүх Гэгээнтнүүдэд зориулагджээ, **ИС**—Т 1:1.

ЕФЕСЧҮҮД, ТЭДЭНД БИЧСЭН

ЗАХИДАЛ. Паул; Паулын захидлуудыг мөн үз

Шинэ Гэрээнд, Ефес дахь Гэгээнтнүүдэд хандан Төлөөлөгч Паулын бичсэн захидал. Уг захидал агуу ач холбогдолтой юм, учир нь энэ нь Христийн Сүмийн тухай Паулын сургаалуудыг агуулдаг.

Бүлэг 1 нь ердийн мэндчилгээг агуулдаг. Бүлэг 2–3 нь хүмүүс Сүмийн гишүүд болох үед Гэгээнтнүүд, харийнхан хийгээд иудейчүүдтэй нэг Сүмд нэгдэн тэдний нөхөд-иргэд болж өөрчлөгддөгийг тайлбарласан байдаг. Бүлэг 4–6 нь Төлөөлөгчид болон бошиглогчдын үүрэг, нэгдэх шаардлага, түүнчлэн Бурханы өвч хуяг дуулгад тавих шаардлагыг тайлбарладаг.

ЕФРАИМ. Иаковын хүү Иосеф; Израил; Манассе; Мормоны Номыг мөн үз

Хуучин Гэрээнд, Иосеф Асенат хоёрын хоёр дахь хүү (**Эхл.** 41:50–52; 46:20). Уламжлалт заншлыг зөрчиж ууган хүү Манассегийн оронд Ефраим залгамжлах эрхийг хүлээн авчээ (**Эхл.** 48:17–20). Ефраим нь Ефраим овгийн эцэг болжээ.

Ефраимын овог: Израил дахь залгамжлах эрхийг Ефраимд өгчээ (**Шаст.** дээд 5:1–2; **Иер.** 31:9). Хожмын өдрүүд дэх тэдний онцгой байдал хийгээд үүрэг хариуцлага

бол санваарыг авч яван, сэргээгдсэн сайн мэдээний захиасыг дэлхийд хүргэн, тараагдсан Израилыг цуглуулах тугийг өргөх болно (Иса. 11:12–13; 2 Ниф. 21:12–13). Ефраимын хүүхдүүд хожмын өдрүүдэд умардын орнуудаас эргэж ирэх тэдэнд алдар суугийн титэм өмсгөх болно (С ба Г 133:26–34).

Ефраимын буюу Иосефын саваа: мэо 600 оны үед Иерусалимаас Америк уруу удирдагдсан Ефраимын овгийн нэг бүлгийн цэдэг. Энэ бүлгийн цэдэг нь Ефраимын буюу Иосефын саваа, эсвэл Мормоны Ном хэмээн нэрлэгддэг. Энэ цэдэг болон Иудейн саваа (Библи) нь нийлж Их Эзэн Есүс Христ түүний амилалт, түүнчлэн Израилын угсааны энэ хоёр хэсгийн дундах түүний бурханлиг ажлын тухай нэгдсэн гэрчлэлийг бүрдүүлдэг.

Ефраимын мөчир хугарч салах болно, мөн Христийн тухай өөр ном бичих болно, **ИСО**, **Эхл.** 50:24–26, 30–31. Иудейн саваа мөн Иосефын саваа нэг болох болно, **Езек.** 37:15–19. Иудейн болон Иосефын бичээсүүд хамтдаа өсөх болно, **2 Ниф.** 3:12. Их Эзэн олон үндэстэнд ярьдаг, **2 Ниф.** 29. Ефраимын савааны түлхүүрүүд Моронайд даатгагдсан байв, **С ба Г** 27:5.

ЕФРАИМЫН САВАА. Ефраим—
Ефраим буюу Иосефын савааг үз

ЕФРОН

Иерусалимаас урагш хорин мильд (гучин хоёр километр) орших Иудейн эртний хот. Энэ бол Абрахам болон түүний гэр бүлийнхнийг оршуулсан газар (**Эхл.** 49:29–32). Энэ хот Давидын хаанчлалын эхэн үед түүний нийслэл байв (2 Сам. 5:3–5).

ЁС БУС, ЁС БУС ЯВДАЛ. Бузар, Бузар булай явдал; Бурханлиг бус; Нүгэл; Сүнсний харанхуй; Шударга бус, Шударга бус явдлыг мөн үз

Хилэнц, алдас; Бурханы зарлигуудад дуулгаваргүй байх.

Би яаж ийм муухай хэрэг үйлдэж Бурхандаа нүгэл үйлдэх билээ? **Эхл.** 39:7–9. ЭЗЭН хар санаатнаас хол байдаг атлаа шударга зөв хүний залбирлыг сонсдог, **Сур.** үгс 15:29. Хар санаат хүн удирдвасаар ард олон халаглана, **Сур.** үгс 29:2 (С ба Г 98:9). Хилэнцэт хүнийг өөрсдийнхөө дундаас зайлуул, **1 Кор.** 5:13. Бид тэнгэрлэг газар дахь бузар муугийн эсрэг тэмцэнэ, **Ефес** 6:12. Ёсон бусыг үйлдэгчдийн дундаас гарч ирцгээ, мөн тэдний цэвэр бус зүйлүүдэд бүү хүрэгтүн, **Алма** 5:56–57 (С ба Г 38:42). Энэ бол ёс бусыг үйлдэгчдийн сүүлчийн байдал юм, **Алма** 34:35 (Алма 40:13–14). Ёсон бус нь хэзээ ч аз жаргал байгаагүй, **Алма** 41:10. Ёсон бусыг үйлдэгчдээр ёсон бусыг үйлдэгчид нь шийтгэгддэг болой, **Морм.** 4:5 (С ба Г 63:33). Тэр цагт зөв шударгыг үйлдэгчид хийгээд ёс бусчууд бүрэн салан тусгаарлах нь тохионо, **С ба Г** 63:54. Ёс бусчуудын төгсгөл ирж байна, **ИС—Мар.** 1:55.

ЁС ЗАНШЛУУД

Нэг үеэс нөгөөд дамжин ирсэн итгэл болон заншил (2 Тес. 2:15). Судруудад, Их Эзэн зөв шударгыг үйлдэгчдийг хүмүүний хилэнцэт ёс заншлуудаас зайлсхийхийг байнга сануулдаг (Лев. 18:30; Марк 7:6–8; Моз. 1:5; С ба Г 93:39–40).

ЁС СУРТАХУУН. Ариун явдал;

Бэлгийн харьцааны ёс суртахуунгүй байдал; Ес бус, Ёс бус явдал; Тачаалалт; Тачаангуйг мөн үз

ЁС СУРТАХУУНГҮЙ ЯВДАЛ.

Ариун явдал; Бэлгийн харилцааны ёс суртахуунгүй явдал; Ёс бус, Ёс бус явдал; Тачаалалт; Тачаангуйг үз

ЁСЛОЛУУД. Аврал; Ариун сүм, Их Эзэний өргөө; Лацдалт, Лацдах; Нас барагсдын аврал; Удмын бичгийг мөн үз

Ариун зан үйлүүд хийгээд ёслолууд.

Ёслолууд нь сүнслэг утга учир бүхий зан үйлүүдээс бүрдсэн байдаг. Ёслолууд нь түүнчлэн Бурханы хуулиуд болон дүрмүүдийн утга санааг илэрхийлж болно.

Сүм дэх ёслолууд нь өвчтөнийг адислах (Иаков 5:14–15), ариун ёслолыг адислах (С ба Г 20:77, 79), усанд умбуулалтаар хийх баптисм (Мат. 3:16; С ба Г 20:72–74), хүүхдийн адислал (С ба Г 20:70), Ариун Сүнс олгох (С ба Г 20:68; 33:15), санваар хүртээх (С ба Г 84:6–16; 107:41–52), ариун сүмийн ёслолууд (С ба Г 124:39), шинэ бөгөөд үүрдийн гэрээн дэх гэрлэлтийг өөртөө багтаадаг (С ба Г 132:19–20).

Ёслолууд болон хуулиудыг тэдэнд заагтун, **Ег.** 18:20. Миний дүрмэн дотор явж мөн миний ёслолуудыг сахигтун, **Езек.** 11:20. Хүмүүс Бурханы ёслолуудыг гүйцэтгэхдээ чанд байв, **Алма** 30:3. Түүний ёслолуудыг сахилаа гэхэд энэ нь бидэнд ямар ашиг өгөх билээ? **3 Ниф.** 24:13–14. Залбирдаг мөн гэмшдэг тэрээр хэрэв миний ёслолуудыг дагах аваас надаар хүлээн зөвшөөрөгддөг бөлгөө, **С ба Г** 52:14–19. Сайн мэдээний хуулиуд хийгээд ёслолуудад дуулгавартай байснаар бүх хүн төрөлхтөн аврагдаж чадна, **ИТ** 1:3.

Төлөөлөх ёслол: Нас барсан хэн нэгний өмнөөс амьд байгаа хүн хийлгэдэг шашны ёслол. Эдгээр ёслолууд нь хэн нэгний төлөө ёслолуудыг хийлгэж байгаа хүмүүс эдгээр ёслолуудыг хүлээн зөвшөөрч, эдгээртэй холбоо бүхий гэрээнүүдийг сахин, Амлалтын Ариун Сүнсээр лацдагдсан үед л зөвхөн үр дүнгээ өгдөг. Ийм ёслолууд эдүгээ ариун сүмүүдийн дотор гүйцэтгэгддэг.

Хэрэв үхэгсэд амилуулагдахгүй бол үхэгсдийн төлөө баптисм хүртэгч нь юу хийж байгаа хэрэг вэ? **1 Кор.** 15:29. Нас барагсдын төлөөх баптисм ариун сүмүүдэд гүйцэтгэгддэг байх ёстой, **С ба Г** 124:29–36. Сүнсний дэлхий дэх сүнснүүдэд нүглүүдийн ангижралын тулд тө-

лөөлөх баптисмыг заадаг байлаа, **С ба Г** 138:29–34.

ЖАКСОН ГҮНЛЭГ, МИССУРИ (АНУ). Шинэ Иерусалимыг

мөн үз

Хожлын өдрүүдэд Гэгээнтнүүдийн цугларах газар; энэ нь тэд Шинэ Иерусалимыг байгуулах гол төв газар юм (С ба Г 57–58; 82; 101:69–71; 105:28).

ЖАРЕД. Жаредчууд; Жаредын ахыг мөн үз

Ахынхаа хамт Бабелын Цамхагаас бөмбөрцгийн өрнөд хагас дахь амлагдсан нутаг уруу эзэмшлийн хүмүүсийг удирдсан Мормоны Номын удирдагч (Ифер 1:33–2:1).

Их Эзэн өөрсдийнх нь гэр бүл, найз нөхдийн хэлийг будлиулахгүй байхын тулд залбирахыг Жаред ахаасаа хүсэв, **Ифер** 1:34–37. Далай уруу очиж мөн тэнд дөрвөн жил амьдрал, **Ифер** 2:13. Амлагдсан нутгийн зүг хөвөв, **Ифер** 6:4–12.

ЖАРЕДЧУУД. Жаред; Жаредын ах; Мормоны Номыг мөн үз

Жаред, түүний ах, түүнчлэн тэдний найз нөхдийн үр удам байсан Мормоны Номон дахь хүмүүс (Ифер 1:33–41). Тэд Бабелын Цамхагаас Америк уруу амлагдсан нутгийн зүг Бурханаар удирдагджээ (Ифер 1:42–43; 2–3; 6:1–18). Тэдний үндэстэн нэгэн цагт сая сая хүмүүс болсон ч гэсэн, ёс бус явдлаас үүдсэн иргэний дайнаар тэд бүгдээрээ устгагджээ (Ифер 14–15).

ЖАРЕДЫН АХ. Жаред; Жаредчуудыг мөн үз

Мормоны Номын бошиглогч. Тэр болон түүний дүү бөмбөрцгийн өрнөд хагас дахь амлагдсан нутаг уруу эзэмшлийн хүмүүсийг удирдах үед жаред үндэстнийг бий болгожээ (Ифер 1–6). Тэрээр Их Эзэнтэй нүүр тулан ярьсан тийм агуу итгэлтэй нэгэн байв (С ба Г 17:1). Түүний түүх Иферийн номонд цэдэглэгдсэн байдаг.

Жаредын ах том мөн хүчит эр, Их Эзэний өндөр ээл хишгийг хүртжээ, **Ифер** 1:34. Жаредын ах аварга итгэлийнхээ учир Их Эзэний хурууг харжээ, **Ифер** 3:6–9 (Ифер 12:20). Христ өөрийн сүнсэн биеийг Жаредын ахад үзүүлэв, **Ифер** 3:13–20. Жаредын ахад илэрхийлэгдсэн тэдгээрээс илүү агуу зүйлүүд хэзээ ч илэрхийлэгдэж байсан нь үгүй, **Ифер** 4:4. Жаредын ах хэмжээгүй эрхт хаант засгийн талаар хүмүүсийг сэрэмжлүүлэв, **Ифер** 6:22–23. Их Эзэн бүх зүйлийг Жаредын ахад үзүүлэв, **Ифер** 12:21. Жаредын ах бичихдээ хүчит нэгэн байв, **Ифер** 12:24. Итгэлээр дамжуулан Жаредын ах Зерин уулыг нүүлгэв, **Ифер** 12:30.

ЖЕРОМ

Мормоны Номон дахь, Иносын хүү мөн Лихайн ачинцар. Тэрээр нифайчуудын цэдгүүдийг мээ 420–361 онд жаран жилийн турш хадгалжээ (Инос 1:25; Жером 1:13). Тэрээр түүхэн цэдэгт ихийг бичихгүй байхаар шийдсэн, итгэл бүхий хүн байлаа (Жером 1:2).

Жеромын ном: Мормоны Номон доторх энэ ном ердөө арван тавхан шүлэгтэй. Нифайчууд Мосегийн хуулиар амьдарч, мөн Христийн ирэлийг ширтэн хүлээсээр байсныг Жером цэдэглэжээ. Итгэлээрээ хүчирхэг эрчүүд байсан хаадаар тэд удирдуулж байв. Бошиглогчид, санваартнууд хийгээд багш нараа анхааралтай сонсож байсан үедээ тэд цэцэглэн хөгжиж байв.

ЖИГШҮҮРТ, ЖИГШҮҮРТ

ХЭРЭГ. Нүглийг *мөн үз.*

Судруудад, зөв шударга болон цэвэр ариун хүмүүсийг жигших буюу үзэн ядахад хүргэдэг ямар нэг зүйл.

Худалч уруулууд Их Эзэнд жигшүүртэй, **Сур. үгс.** 12:22. Бардамнал Их Эзэний мэлмийд жигшүүртэй, **Иаков** 2:13–22. Өөрсдийнхөө жигшүүрт хэргүүдийг үзэх нь ёс бусчуудад оногдсон болой, **Моз.** 3:25. Ариун

бус явдал нь аллага болон Ариун Сүнсийг үгүйсгэхээс бусад нүглүүдээс хамгийн жигшүүртэй нь юм, **Алма** 39:3–5. Тэдний жигшүүрт хэргүүдийн эсрэг Их Эзэний зөвүүлэл дүрэлзэж байна, **С ба Г** 97:24.

ЖИГШҮҮРТ СҮМ. Чөтгөр—

Чөтгөрийн сүмийг үз

ЖИШИГ БҮТЭЭЛҮҮД.

Каноныг үз

ЗААХ, БАГШ. Ариун Сүнсийг

мөн үз

Бусад мэдлэг, ялангуяа сайн мэдээний үнэнийг өгөх хийгээд тэднийг зөв шударга ёс уруу хөтлөх. Сайн Мэдээг заадаг хүмүүс Сүнсээр зааварлагдах ёстой. Бүх эцэг эхчүүд гэр бүлдээ багш юм. Их Эзэн болон түүний удирдагчдаас ирэх зааврыг Гэгээнтнүүд эрэлхийлж хүлээн авахад бэлэн байх ёстой.

Тэдгээрийг хөвгүүддээ заа, **Дэд хууль** 4:8–9. Та нар тэдгээрийг хүүхдүүддээ хичээнгүйлэн заа, **Дэд хууль** 6:7 (Дэд хууль 11:18–19). Явах ёстой замаар нь замнуулахын тулд хүүхдийг сурга, **Сур.** үгс 22:6. Та нарын хүүхдүүд Их Эзэнээр сургагдах ёстой, **Иса.** 54:13 (3 Ниф. 22:13). Та бол Бурханаас ирсэн багш гэдгийг бид мэднэ, **Иохан** 3:2. Бусад заагч та өөртөө заадаггүй бус уу? **Ром** 2:21. Бибээр эцгийнхээ бүхий л эрдэм мэдлэгт зарим талаар сургагдсан билээ, **1 Ниф.** 1:1 (Инос 1:1). Санваартан, болон багш нар хичээнгүйлэн заах буюу хүмүүсийн нүглийг өөрсдийнхөө толгой дээр хариулах ёстой, **Иаков** 1:18–19. Намайг сонсож, мөн сонороо дэлгэгтүн, **Моз.** 2:9. Та нар хүүхдүүддээ нэг нэгнийгээ хайрлаж мөн үйлчлэхийг заах ёстой, **Моз.** 4:15. Тэрээр Бурханаас бус аваас, хэнийг ч багш хэмээн бүү итгэ, **Моз.** 23:14. Үгийг хүлээн авахад бэлтгэхээр Их Эзэн өөрийн Сүнсийг уг нутгийн бүхий л гадаргуу дээр юүлсэн болой, **Алма** 16:16. Тэд Бурханы хүч мөн

эрх мэдлээр заав, **Алма** 17:2–3. Тэд эхчүүдээрээ сургагдсан байлаа, **Алма** 56:47 (Алма 57:21). Тэд мэргэн ухааныг хайхын хэрээр тэд итгэмжлэгдэж болно, **С ба Г** 1:26. Та нарт миний томилсон албан тушаалын дагуу бие биендээ заа, **С ба Г** 38:23. Библи болон Мормоны Номон дахь миний сайн мэдээний зарчмуудыг заа, **С ба Г** 42:12. Чибээр дээрээс заагдах болно, **С ба Г** 43:15–16. Эцэг эхчүүд хүүхдүүддээ заах ёстой, **С ба Г** 68:25–28. Хаант улсын сургаагыг бие биендээ заа, **С ба Г** 88:77–78, 118. Өөрсдийнхөө дунд багшийг томил, **С ба Г** 88:122. Та нар хүүхдүүддээ гэрэл ба үнэнийг заагаагүй нь зовлонгийн тань шалтгаан болой, **С ба Г** 93:39–42. Эдгээр зүйлүүдийг хүүхдүүддээ чөлөөтэйгээр заа, **Моце** 6:57–61.

Сүнсээр заах: Яригч бол та нар бус, та нарын дотор яригч Сүнс юм, **Мат.** 10:19–20. Судрыг бидэнд тайлбарлахад дотор маань шатаж байсан бус уу? **Лук** 24:32. Сайн мэдээ Сүнсний хүчээр номлогддог, **1 Кор.** 2:1–14. Тэрээр Бурханы хүч хийгээд эрх мэдлээр ярив, **Моз.** 13:5–9 (Алма 17:3; Хил. 5:17). Хүмүүнийг итгүүлэн үнэмшүүлэхэд миний Сүнс чамд байх болно, **С ба Г** 11:21. Тайтгаруулагчаар чиний заах бүх зүйлд чамайг сонсох болно, **С ба Г** 28:1 (С ба Г 52:9). Хэрэв чи Сүнсийг хүлээн аваагүй бол, чи заах ёсгүй, **С ба Г** 42:14 (С ба Г 42:6). Хүмүүний үрст миний Сүнсний хүчээр эдгээр зүйлсийг заа, **С ба Г** 43:15. Ахлагч нар Сүнсээр сайн мэдээг заах ёстой, **С ба Г** 50:13–22. Чи юу хэлэх нь яг тэр үед чамд өгөгдөх болно, **С ба Г** 84:85 (С ба Г 100:5–8).

ЗАВХАЙРАЛ. Ариун явдал;
Садар самуун; Тачаадалт;
Тачаангуйг мөн үз

Бие биентэйгээ гэрлээгүй хоёр хүн хууль бусаар бэлгийн харьцаанд орох. Судруудад үүнийг заримдаа урвалтын бэлэгдэл болгон хэрэглэсэн байдаг.

Намайг бүү доромжлооч, учир нь ийм зүйл хийж болохгүй шүү дээ, **2 Сам.** 13:12. Завхайрлаас цээрлэж яв, **Үйлс** 15:20. Бие нь завхайрлын тулд бус, харин Бурханы төлөө юм, **1 Кор.** 6:13–18. Завхайрлаас зайлсхийхийн тулд, эр хүн бүр өөрийн эхнэртэй байг, **1 Кор.** 7:2–3. Та нар завхайрлаас зайлсхийх ёстой нь Бурханы таалал билээ, **1 Тес.** 4:3. Иаков Нифайн хүмүүст завхайрлын эсрэг сануулав, **Иаков** 3:12. Та нар аллагуудынхаа, мөн завхайрлынхаа учир устгалд боловсорч байна, **Хил.** 8:26. Сүмд нэгдэхийн тулд завхайрагчид наманчлах ёстой, **С ба Г** 42:74–78.

ЗАГАЛМАЙ. Ариун ёслол; Есүс Христ; Голгота; Цагаатгал, Цагаатгах; Цовдлолтыг мөн үз

Есүс Христ дээр нь цовдлуулсан модон байгууламж (Марк 15:20–26). Эдүгээ дэлхийд олон хүн энэ нь Христийн цовдлолт болон цагаатгагч золиослол гэж боддог; гэсэн хэдий ч Их Эзэн өөрийн цовдлолт болон цагаатгалын бэлэгдэл— ариун ёслолын талх усыг бий болгожээ (Мат. 26:26–28 С ба Г 20:40, 75–79). Сударт гардаг загалмайгаа үүрэх тэд өөрсдийгөө бурханлиг бус явдал хийгээд дэлхийн аливаа шунал тачаалаас татгалзан мөн түүний зарлигуудыг сахихын тулд Есүс Христийг маш их хайрладаг хүмүүс юм. (ИСО, Мат. 16:25–26).

Загалмайгаа үүрч, мөн намайг дага, **Марк** 10:21 (3 Ниф. 12:30; С ба Г 23:6). Есүс загалмайг тэвчсэн бөгөөд Бурханы сэнтийний баруун гар талд заларсан, **Евр.** 12:2. Тэрбээр загалмайд өлгөгдөн мөн дэлхийн нүглүүдийн тул алагдсан билээ, **1 Ниф.** 11:33. Дэлхийн загалмайнуудыг тэвчсэн тэд Бурханы хаант улсыг өвлөнө, **2 Ниф.** 9:18. Би загалмай дээр өргөгдөж болохын тулд Эцэг минь намайг илгээсэн болой, **3 Ниф.** 27:14–15. Загалмайгаа үүрч мөн намайг үл дагах, мөн миний зарлигуудыг үл сахих тэрээр, мөн аврагдах нь үгүй бөлгөө, **С ба Г** 56:2. Хүний

Хүү загалмай дээр өргөгдсөнийг болгоогтун, **Моце** 7:55.

ЗАГВАР

Тодорхой үр дүнд хүрэхийн тулд, хүний баримталж болох загвар. Судруудад загвар нь ихэвчлэн тодорхой арга замыг харуулах буюу эсвэл ямар нэг юмыг бий болгох үлгэр загвар гэсэн утгатай байдаг.

Мосед үзүүлэгдсэн загварын дагуу асар барихаар Эзэн Израилд зарлиглав, **Ег.** 25. Ариун сүм барих загварыг Давид Соломонд өгөв, **Шаст.** дээд. 28:11–13. Өөрт нь итгэх хүмүүст үлгэр дуурайл болгон Есүс Христ надад гэвчээрийг харуулж болно, **1 Тим.** 1:16. Та нар мэхлэгдэхгүй байж болохын тулд, бибээр чамд бүх зүйлд загвар өгнө, **С ба Г** 52:14.

ЗАЛБИРАЛ. Амен; Асуух;

Бишрэн шүтэх; Тунгаан
бодохыг мөн үз

Бурханд хандан хүн баяр талархлаа илэрхийлж мөн адислалуудыг хүсдэг хүндэтгэл бүхий харьцаа. Залбирлууд нь Есүс Христийн нэрээр Бурханд хандсан байдаг. Залбирлыг чанга дуугаар болон чимээгүй дотроо хийж болно. Хэрэв хүний бодол санаанууд Бурханд хандсан байвал тэдгээр нь залбирал болж болно. Зөв шударга хүмүүсийн дуулсан дуу Бурханд хандсан залбирал болж чадна (**С ба Г** 25:12)

Залбирлын зорилго нь Бурханы тааллыг өөрчилдөггүй боловч, биднийг аюулгүй байлгаж мөн бусдын төлөөх залбирлуудыг Бурхан соёргоход бэлэн байдаг хэдий ч, бид үүнийг олж авахын төлөө гуйн хүсэх ёстой.

Бид Эцэгт хандан Христийн нэрээр залбирдаг (**Иохан** 14:13–14; 16:23–24). Бидний хүсэл Христийн хүсэл байгаа үед бид Христийн нэрээр үнэнхүү залбирах боломжтой байдаг (**Иохан** 15:7; **С ба Г** 46:30). Бид зөв зүйлүүдийг хүсэхэд энэ нь Бурханы хувьд өгөхөд боломжтой

байдаг (**3 Ниф.** 18:20). Зарим залбирлууд хариулагдахгүй үлддэг, учир нь тэдгээр нь Христийн хүслийг төлөөлөх байдлаар биш, харин хүмүүний амин хувиа хичээх үзлээс үүдэлтэй байдаг (**Иаков** 4:3; **С ба Г** 46:9). Чухамдаа бол, хэрэв бид зөв шударга бус зүйлийг хүсэх юм бол, энэ нь бидэнд зэмлэл болон хувирах болно (**С ба Г** 88:65).

Тэр цагаас эхлэн хүмүүс ЭЗЭНий нэрийг дуудах болжээ, **Эхл.** 4:26. Тахилын ширээний газарт Абрахам ЭЗЭНий нэрийг дуудав, **Эхл.** 13:4. Исаакт эхнэр олоход нь туслаач хэмээн Абрахамын зарц залбирал, **Эхл.** 24:10–19. Би та нарын төлөө залбирахгүйгээс болж ЭЗЭНий эсрэг нүгэл үйлдэх нь надаас хол байг, **1 Сам.** 12:23. ЭЗЭН зөв шударга хүний залбирлыг сонсдог, **Сур.** үгс 15:29. Та нар бүх зүрх сэтгэлээрээ намайг эрсэн үед та нар намайг олно, **Иер.** 29:12–13. Та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбир, **Мат.** 5:44 (**Лук** 6:28; **3 Ниф.** 12:44). Нууцаар оршигч Эцэгтээ залбир, **Мат.** 6:5–8 (**3 Ниф.** 13:5–8). Тиймийн тул энэ маягаар залбир та нар, **Мат.** 6:9–13 (**Лук** 11:2; **3 Ниф.** 13:9). Гуй, тэгвэл та нарт өгнө, **Мат.** 7:7 (**3 Ниф.** 14:7; **С ба Г** 4:7; 6:5; 66:9). Есүс ганцаар залбирахаар ууланд гарчээ, **Мат.** 14:23. Уруу таталтад орохгүйн тулд сэргэг бай, залбир, **Мат.** 26:41 (**Марк** 14:38; **3 Ниф.** 18:15–18; **С ба Г** 31:12). Тэрээр ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйг, **Иаков** 1:5–6 (**С ба Г** 42:68; 46:7). Зөвт хүний залбирал нь үр нөлөөтэй бөгөөд ихийг гүйцэлдүүлж чадна, **Иаков** 5:16. Хүмүүнд залбирахыг сургах тэр Сүнснийг сонсогтун, **2 Ниф.** 32:8–9. Хүчит залбирлаар би түүнээс гуйсан, **Инос** 1:4. Би олон өдөр мацаг барьж мөн мацаг барилтанд зориулсан байв, **Алма** 5:45–46 (**Алма** 26:22). Тэд агуу залбирал хийгээд мацаг барилтад өөрсдийгөө зориулж байв, **Алма** 17:3. Залбирал эсвээс шүтлэгийн талаар Зинос юу хэлснийг та нар санаж байна уу? **Алма** 33:3. Өөрсдийгөө даруусгаж, мөн залбиралд

үргэлжлүүлэгтүн, **Алма** 34:18–27. Өөрийн бүхий л үйлүүдэд Их Эзэнтэй зөвлө, **Алма** 37:37. Та нар миний нэрээр Эцэгт үргэлж залбирах ёстой, **3 Ниф.** 18:19–20. Гэр бүлдээ залбир, **3 Ниф.** 18:21. Есүс Эцэгт залбирав, **3 Ниф.** 19:31–34 (Иохан 17; **3 Ниф.** 18:16). Тэд зүрх сэтгэлдээ залбирахаа үл зогсохыг тэрбээр тэдэнд зарлиглав, **3 Ниф.** 20:1. Хэрэв тэрээр залбирахдаа зүрх сэтгэлийнхээ үнэн хүслээр биш аваас, энэ нь түүнд ямар ч ашиггүй, **Моро.** 7:6–9. Асуух ёсгүй тэр зүйлийн төлөө чи бүү гуй, **С ба Г** 8:10. Ялан дийлэгч болж гарахын тулд чи ямагт залбир, **С ба Г** 10:5. Чи чангаар хийгээд түүнчлэн зүрх сэтгэлдээ залбирах ёстой хэмээн би чамд зарлиглаж байна, **С ба Г** 19:28. Итгэлийн залбирлаар Сүнс чамд өгөгдөх болно, **С ба Г** 42:14. Залбирлын өргөөнд очиж мөн ариун ёслолоо өргөгтүн, **С ба Г** 59:9 (Мат. 21:13). Эцэг эхчүүд хүүхдүүддээ залбирахыг заах ёстой, **С ба Г** 68:28. Тэдний Бурхан Их Эзэн тэдний залбирлуудыг сонсохдоо удаан буюу, **С ба Г** 101:7–8 (Моз. 21:15). Чи даруу бай, ингэвэл чиний Бурхан Их Эзэн залбирлуудад чинь хариу өгөх болно, **С ба Г** 112:10. Хүүгийн нэрээр Эцэгийг дуудахаар Адам зарлиг болгогдов, **Моце** 5:8. Эцэг Хүү хоёр түүний залбиралд хариулахаар Иосеф Смит дээр хүрч иржээ, **ИС**—Т 1:11–20.

ЗАЛХУУ, ЗАЛХУУ ХОЙРГО БАЙДАЛ

Идэвхгүй, зөв ажил үйлст оролцдоггүй.

Хэрэв хэн нэг нь ажил хийхгүй бол, бүү идэг, **2 Тес.** 3:10. Тэд зальт аргаар дүүрэн, залхуу хүмүүс болов, **2 Ниф.** 5:24. Чи залхаг байдлаас татгалз, **Алма** 38:12. Залхуу тэрээр хөдөлмөрлөгчийн талхнаас идэх ёсгүй, **С ба Г** 42:42. Өөрийн гараар хөдөлмөрлөдөггүй та нарт халаг, **С ба Г** 56:17. Сайн зарчимд санаа сэтгэлээ зориулдаг бай, **С ба Г** 58:27. Залхуу байхаа болигтун, **С ба Г** 88:124.

ЗАЛЬ МЭХ. Залилан мэхлэх, Ов мэх, Хууран мэхлэхийг мөн үз

Судруудад заль мэх нь хууран мэхлэх явдал байдаг.

Сүнсэндээ заль мэхгүй хүн юутай ерөөлтэй, **Дуул.** 32:2 (Дуул. 34:13; **1 Петр** 2:1). Наганаел бол дотроо заль мэхгүй израил хүн байлаа, **Иохан** 1:47 (С ба Г 41:9–11). Цэвэр мэдлэг нь заль мэхгүй бодгалийг өргөжүүлэн тэлдэг, **С ба Г** 121:42.

**ЗАЛЬ МЭХ, ЗАЛИЛАХ,
ЗАЛИЛАН.** Ов мэх; Худал хэлэхийг мөн үз

Судруудад, залилан мэхлэх нь хэн нэгнийг ямар нэгэн үнэн бус зүйлд итгүүлэхэд хүргэх явдал юм.

Худал тангараг тавиагүй хүн Их Эзэний уул өөд авирна, **Дуул.** 24:4. Хуурмаг хүнээс намайг авраач, **Дуул.** 43:1. Мууг сайн, сайныг муу гэж нэрлэгчид гаслантай яа, **Иса.** 5:20 (2 Ниф. 15:20). Хэн ч өөрийгөө бүү мэхлэг, **1 Кор.** 3:18. Хэн ч та нарыг хоосон үгээрээ бүү мэхлэг, **Ефес** 5:6. Харин хилэнцтэн хуурч мөн хуурагдана, **2 Тим.** 3:13. Бүх дэлхийг мэхэлсэн Сатан доош хаягдсан байв, **Илч.** 12:9. Үндэстнүүдийг дахин мэхлэхгүйн тулд Сатан хүлэгдсэн байв, **Илч.** 20:1–3. Их Эзэн мэхлэгдэх боломжгүй, **2 Ниф.** 9:41. Бурханы өмнө мэхлэхийг үл үйлдэн, Хүүг дагавал та нар Ариун Сүнсийг хүлээн авах болно, **2 Ниф.** 31:13. Шерем чөтгөрийн хүчээр мэхлэгдсэн байснаа хүлээв, **Иаков** 7:18. Ноа Хааны хүмүүс зусар үгсээр мэхлэгдсэн байв, **Моз.** 11:7. Ухаантай хүмүүс Ариун Сүнсийг хөтчөө болгон мөн мэхлэгддэггүй, **С ба Г** 45:57. Мэхлэгчдэд халаг, **С ба Г** 50:6. Тэр Сатан, бүх худал хуурмагийн хаан болж, хүнийг мэхэлж мөн харалган болгосон буюу, **Моце** 4:4.

ЗАМ. Алхах, Бурхантай хамт алхах; Есүс Христийг мөн үз

Хүний дагах зам буюу чиглэл. Есүс

өөрийгөө зам хэмээн хэлжээ (Иохан 14:4–6).

Их Эзэний зарлигуудыг түүний замаар алхан сахь, **Дэд хууль** 8:6. Хүүхдийг явах ёстой замаар нь сурга, **Сур. үгс** 22:6 (2 Ниф. 4:5). Их Эзэн хэлэхдээ түүний зам бол бидний-хээс илүү юм гэжээ, **Иса.** 55:8–9. Амь уруу хөтөлдөг хаалга нь жижиг, зам нь нарийн юм, **Мат.** 7:13–14 (3 Ниф. 14:13–14; 3 Ниф. 27:33; С ба Г 132:22, 25). Бурхан уруу таталтаас зайлах замыг чамд хийж өгөх болно, **1 Кор.** 10:13. Их Эзэн зарлигийг гүйцэлдүүлэх замыг тэдэнд зэхэлгүйгээр хүмүүний үрст зарлигийг өгдөггүй, **1 Ниф.** 3:7 (1 Ниф. 9:6; 17:3, 13). Тэр хаалганаас өөр зам гэж үгүй, **2 Ниф.** 9:41. Та нар үүрдийн үхэл эсвээс мөнх амьдралын замыг сонгох—өөрсдийнхөө төлөө үйлдэх эрх чөлөөтэй, **2 Ниф.** 10:23. Энэ нь зам бөгөөд өөр ямар ч зам буюу нэр байхгүй, **2 Ниф.** 31:21 (Моз. 3:17; Алма 38:9; Хил. 5:9). Өөрийн хүүгийн бэлгээр Бурхан илүүтэй онцгой замыг бэлтгэсэн бөлгөө, **Ифер** 12:11 (1 Кор. 12:31). Хүн бүр өөрсдийнхөө замаар алхдаг, **С ба Г** 1:16. Энэ нь миний өөрийн замаар үйлдэгдэх шаардлагатай, **С ба Г** 104:16.

ЗАН АРАНШИН. Уурыг үз

ЗАРАХЕМЛА. Аммон; Мулекийг *мөн үз*

Мормоны Номонд, Зарахемла нь (1) Мулекийн эзэмшлийг удирдсан хүн, (2) түүний нэрээр нэрлэгдсэн хот, (3) Зарахемлагийн нутаг буюу (4) түүнийг дагасан хүмүүс юм.

Их Эзэн нифайчуудыг илгээсэнд Зарахемла баярлав, **Омнаи** 1:14. Зарахемла эцэг өвгөдийнхөө уг удмыг өгөв, **Омнаи** 1:18. Аммон Зарахемлагийн удмынх байв, **Моз.** 7:3, 13. Зарахемла хотод Сүм зохион байгуулагдав, **Алма** 5:2. Зөв шударгыг үйлдэгчдийн улмаас ёс бусчууд Зарахемлад аврагджээ, **Хил.** 13:12. Зарахемла хот Христийн нас баралтаар шатжээ, **3 Ниф.** 8:8, 24.

ЗАРЛИГУУДЫН НОМ. Илчлэлт; Сургаал ба Гэрээг *мөн үз*

1833 онд Бошиглогч Иосеф Смитээр хүлээн авагдсан нилээд хэдэн илчлэлт A Book of Commandments for the Governments of the Church of Christ (*Христийн Сүмийн удирдлагад өгсөн зарлигуудын ном*) гэсэн нэртэйгээр хэвлэлтэд бэлтгэгджээ. Их Эзэн өөрийн үйлчлэгчидтэй харилцаагаа үргэлжлүүлж, тийнхүү илчлэлтүүдийн цуглуулга томрон хоёр жилийн дараа Сургаал ба Гэрээ нэртэйгээр хэвлэгдсэн байна.

С ба Г 1 бол Их Эзэний зарлигуудын номны өмнөх үг юм, **С ба Г** 1:6. Их Эзэн Зарлигуудын номныхоо өчүүхэн хэсгийг хувилан хэвлүүлэхээр хамгийн ухаалаг хүнийг сорьдог ажээ, **С ба Г** 67:4–9. Илчлэлтүүдийг хэвлүүлэхээр даамлууд томилогдов, **С ба Г** 70:1–5.

ЗАРЧИМ. Сайн Мэдээг *мөн үз*

Үндсэн сургаал, үнэн буюу хууль. Сайн Мэдээний анхдагч зарчмууд нь Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл хийгээд наманчлал мөн (ИТ 1:4).

Христийн сургаалын зарчмуудыг орхилгүйгээр, төгөлдөржилт уруу тэмүүлцгээе, **Евр.** 6:1–3. Ахлагчид, санваартнууд мөн багш нар судруудад байдаг миний сайн мэдээний зарчмуудыг заах болно, **С ба Г** 42:12. Зарчимд, сургаалд, мөн бүх зүйлд илүү төгс зааварлагдагтун, **С ба Г** 88:78 (С ба Г 97:14). Түүнд миний өгсөн ёс суртахууны сонгох эрхийн дагуу хүн болгон сургаа хийгээд зарчимд үйлдэж болно, **С ба Г** 101:78. Оюун билгийн ямар ч зарчимд бид энэ амьдралд хүрлээ гэхэд, амилуулалтад энэ нь бидэнтэй хамт сэргэн босох болно, **С ба Г** 130:18–19.

ЗАРЧИМЧ БАЙДАЛ. Зөв шударга, Зөв шударга ёс; Шударга, Шударга ёсыг *мөн үз*

Зөв шударга ёс, шударга ёс ба чин үнэнч чанар.

Үхэн үхтлээ би үнэнч байдлаа өөрөөсөө холдуулахгүй, **Иов** 27:5. Шударга зөв хүн өөрийн зарчимч байдалд явдаг, **Сур. үгс** 20:7. Тэд итгэж даалгасан ямар ч зүйлд цаг үргэлж үнэнч эрс билээ, **Алма** 53:20. Зүрх сэтгэлийнх нь үнэнчийн учир Их Эзэн Хайрум Смитийг хайрладаг байв, **С ба Г** 124:5.

ЗАСГИЙН ГАЗАР. Үндсэн хуулийг мөн үз

Есүс Христ эргэж ирээд, зөв шударга засгийн газрыг байгуулах болно. Засаглал түүний мөрөн дээр байх болно, **Иса.** 9:6 (2 Ниф. 19:6) Цезарийн юмсыг Цезарьт нь өг, **Мат.** 22:21 (С ба Г 63:26). Дээд эрх мэдлүүдэд захирагд, **Ром** 13:1. Хаад, түүнчлэн эрх мэдэлд буй бүгдийн төлөө залбирагтун, **1 Тим.** 2:1–2. Удирдагчид ба эрх баригчдад захирагдаж, дуулгавартай бай, **Тит** 3:1. Эзэний төлөө өөрсдийгөө аливаа хүний ёсонд захируул, **1 Петр** 2:13–14. Есүс Христ дэлхийн дээд захирагч байх болно, **Илч** 11:15. Шударга эрчүүдийг өөрийн хаан болгодог бай, **Моз.** 23:8. Ажил хэргээ хүмүүсийн саналаар хий, **Моз.** 29:26. Христ ирэхдээ бидний жолоодогч байх болно, **С ба Г** 41:4. Бурханы хуулиудыг сахьдаг хүнд улс орныхоо хуулиудыг зөрчих шаардлага байхгүй, **С ба Г** 58:21. Ёс бусчууд засаглахад, хүмүүс гашууддаг **С ба Г** 98:9–10. Засгийн газрууд нь хүмүүн төрөлхтний ашиг тусын тулд Бурханаар эмхлэгдэн байгуулагддаг, **С ба Г** 134:1–5. Бүх хүмүүс засгийн газруудыг дэмжиж мөн тулах үүрэгтэй, **С ба Г** 134:5. Хаад, ерөнхийлөгчид, удирдагчид, мөн шүүгчдэд захирагддаг байхад бид итгэдэг, **ИТ.** 1:12

ЗАХАРИА. Елизабет; Иохан Баптистыг мөн үз

Шинэ Гэрээнд, Иохан Баптистын эцэг. Захариа санваарын албан тушаалтай байсан бөгөөд ариун сүмд ажилладаг байжээ.

Тэнгэр элч Габриел Захариа түүний эхнэр Елизабет хоёрт хүү амлажээ,

Лук 1:5–25 (С ба Г 27:7). Тэрээр хэлгүй болов, **Лук** 1:59–79. Захариа ариун сүм тахилын ширээ хоёрын хооронд алагдсан байжээ, **Мат.** 23:35 (Лук 11:51).

ЗЕБУЛУН. Израил; Исаакийн хүү Иаковыг мөн үз

Хуучин Гэрээнд, Иаков Леа хоёрын хүү (Эхл. 30:19–20).

Зебулуны овог: Иаков Зебулуны овгийг адисалжээ (Эхл. 49:13). Зебулуны овог Дебора Барак нартай Израилын дайснуудын эсрэг тулалдаанд нэгджээ (Шүүгч. 4:4–6, 10). Тэд тэрчлэн мидианчуудтай байлдахаар Гидеонтой нэгдэв (Шүүгч. 6:33–35).

ЗЕДЕКИА. Мюлекийг мөн үз

Хуучин Гэрээнд Иудейн сүүлчийн хаан (Хаад дэд 24:17–20; 25:2–7). Зедекиа бошиглогч Иеремиаг шоронд хорьсон (Иер. 32:1–5) бөгөөд Иеремиа Зедекиагийн боолчлолыг бошигложээ (Иер. 34:2–8, 21). Зедекиагийн хаанчлалын эхний жил Лихай болон түүний гэр бүл Иерусалимд амьдарч байв (1 Ниф. 1:4). Зедекиагийн нэгээс бусад бүх хөвгүүд нь алагджээ; түүний хүү Мюлек дэлхийн бөмбөрцгийн баруун хагас уруу зугтсан ажээ (Иер. 52:10; Омнай 1:15; Хил. 8:21).

ЗЕНИФ

Мормоны Номонд, Нифайн газар нутаг уруу бүлэг хүмүүсийг удирдан дагуулсан хүн; тэрээр тэдний хаан болж, мөн тэднийг зөв шударгаар удирдаж байв (Моз. 9–10).

ЗЕНОК

Зөвхөн Мормоны Номонд дурдагддаг, Хуучин Гэрээний үе дэх Израилын бошиглогч.

Христийн нас баралтыг бошигложээ, **1 Ниф.** 19:10. Бурханы Хүүгийн тухай ярих, **Алма** 33:15 (Алма 34:7). Үнэний төлөө алуулжээ, **Алма** 33:17. Мессиагийн ирэлтийн талаар бошиглосон ажээ, **Хил.** 8:20.

ЗЕНОС

Христийн үүрэг зорилгын талаар бошиглолууд нь зөвхөн Мормоны Номоос гардаг Хуучин Гэрээний үеийн Израилын бошиглогч.

Христийн оршуулга болон гурван өдрийн харанхуйг бошигложээ, **1 Ниф.** 19:10. Израилын цугларалтыг угтан хэлжээ, **1 Ниф.** 19:16. Иаков Зеносын таримал болон зэрлэг чидуш моддын сургаалт зүйрлэлийг иш татсан байв, **Иаков** 5. Иаков Зеносын ёгтлолыг тайлбарлажээ, **Иаков** 6:1–10. Залбирал болон шүтэн бишрэх талаар заав, **Алма** 33:3–11. Гэтэлгэл Хүүгээр дамжин ирэхийг заажээ, **Алма** 34:7. Зоримог гэрчлэлийнхээ улмаас алуулав, **Хил.** 8:19. Лемэнчүүдийн сэргээлтийн тухай яриу, **Хил.** 15:11. Христийн нас баралтын үеийн сүйрлийг гэрчилжээ, **3 Ниф.** 10:15–16.

ЗЕРУББАБЕЛ

Хуучин Гэрээнд, Палестин уруу буцах зөвшөөрлийг Сирийн хаан иудейчүүдэд өгөхөд Зеруббабел Иудейн хааны ордны захирагч буюу төлөөлөгчөөр томилогджээ. Түүний перс нэр нь Шешбаззар юм (Езра 1:8). Тэрээр Иерусалимд ариун сүмийг дахин барихад оролцсон байна (Езра 3:2, 8; 5:2).

ЗЕФАНИЯ

Иошиагийн хаанчлалын үед амьдарч байсан Хуучин Гэрээний бошиглогч (мэв 639–608).

Зефаниагийн ном. Бүлэг 1 нь хилэгнэл болон гай зовлонгоор дүүрэн байх ирэх өдрийн тухай өгүүлдэг. Бүлэг 2 нь зөв шударгыг болон номхон дөлгөөн байдлыг эрэлхийлэхийг Израилын хүмүүст сануулжээ. Бүлэг 3 нь Хоёр дахь Ирэлтийн үед бүх үндэстэн тулалдаанд цугларах тухай өгүүлдэг. Гэсэн хэдий ч, Их Эзэн тэдний дунд хаанчлах болно.

ЗЕХАРИА

мэв 520 оны орчим бошиглож

байсан Хуучин Гэрээний бошиглогч. Тэрээр мөн Хаггаин үед амьдарч байжээ (Езра 5:1; 6:14).

Зехариагийн ном. Христийн мөнх бус үеийн тохинуулал хийгээд түүний хоёр дахь ирэлтийн тухай бошиглолуудаараа энэ ном нэрд гарсан юм (Зех. 9:9; 11:12–13; 12:10; 13:6). Бүлэг 1–8 нь Бурханы хүмүүсийн ирээдүйн тухай хэд хэдэн зөгсдлийг агуулдаг. Бүлэг 9–14 нь Мессиа, хожмын өдрүүд, Израилын цугларалт, эцсийн агуу дайн болон Хоёр дахь Ирэлтийн тухай үзэгдлүүдийг агуулдаг.

ЗИЕЗРОМ

Мормоны Номон дахь Аммониха хотын хуульч. Алма Амюлек хоёр Зиезром худлаа хэлж байгааг Сүнсний хүчээр мэджээ. Дараа нь тэрээр Христийн сайн мэдээнд хөрвүүлэгдсэн ажээ (Алма 11:21–46; 15:1–12).

ЗИППОРА. Мосег мөн үз

Хуучин Гэрээнд, Мосегийн эхнэр, Иетрогийн охин (Ег. 2:21; 18:2).

ЗОЛИОСЛОЛ. Ариун ёслол; Есүс

Христ; Харууссан зүрх;
Цагаатгал, Цагаатгах; Цусыг
мөн үз

Эрт цагт *золиослол* гэдэг нь хэн нэгийг буюу ямар нэг зүйлийг ариун болгохыг хэлдэг байв. Эүгээ энэ нь Их Эзэн болон түүний хаант улсын төлөө дэлхийн зүйлүүдийг орхих буюу хохирол хүлээх гэсэн утгатай болжээ. Их Эзэний Сүмийн гишүүд Их Эзэний төлөө бүх зүйлээ золиослоход бэлэн байх ёстой. “Бүх зүйлийг золиослохыг шаарддаггүй шашин амьдрал хийгээд авралд зайлшгүй шаардлагатай итгэлийг төрүүлэх хангалттай хүчтэй хэзээ ч байдаггүй хэмээн Иосеф Смит сургасан байдаг. Мөнхийн хэтийн төлөвт золиослолоор олж авсан адислалууд нь золиосолсон аливаа зүйлээс илүү агуу байдаг.

Адам Ева хоёрыг Еденийн Цэцэрлэгээс хөөгдсөний дараа Их Эзэн

тэдэнд золиослолын хуулийг өгчээ. Сүргийнхээ анхны төлийг өргөх нь энэ хуульд байлаа. Уг золиослол нь Бурханы Төрсөн Ганц Хүүгээр хийгдэх золиослолыг бэлгэддэг байв (Мосе 5:4–8). Энэ заншил нь амьтныг золиосолдог сайн мэдээний ёслолын төгсгөл болох Есүс Христийн үхлийг хүртэл үргэлжилж байв (Алма 34:13–14). Өнөөдөр Сүмд гишүүд Есүс Христийн золиослолыг дурсан санаж талх, усны ариун ёслолоос хүртдэг. Харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийг өргөл болгохыг өнөөдөр тэрчлэн Христийн Сүмийн гишүүдээс хүсдэг (3 Ниф. 9:19–22). Энэ нь тэд даруу, наманчилдаг, мөн Бурханы зарлигуудыг дуулгавартай дагахад бэлэн байна гэсэн утгатай юм.

Абрахам хүү Исаакаа хүлэн мөн түүнийг тахилын ширээн дээр тавив, **Эхл.** 22:1–18 (Иаков 4:5). Та нар өөрсдийн шатаалт тахилыг золиослох ёстой, **Ег.** 20:24. Тахилд өргөх мал өө сэвгүй байх ёстой, **Дэд хууль** 15:19–21. Дуулгавартай дагах нь золиослолоос илүү дээр, **1 Сам.** 15:22. Хайрлах нь бүх шатаалт тахил болон золиослолуудаас илүү дээр, **Марк** 12:32–33. Есүс Христийн золиослолоор дамжин бид ариун болгогдсон билээ, **Евр.** 10:10–14. Христ өөрийгөө нүглийн золиос болгон өргөсөн, **2 Ниф.** 2:6–7. Тэрхүү агуу хийгээд сүүлчийн золиослол нь Бурханы Хүү байх болно, тиймээ, хэмжээлшгүй мөн мөнхийн бөлгөө, **Алма** 34:8–14. Шатаалт тахилыг дахин бүү өргө; харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийг Бурханд золиосол, **3 Ниф.** 9:19–20 (Дуул. 51:16–17; **С ба Г** 59:8). Өнөөдөр бол золиослолын өдөр, **С ба Г** 64:23 (**С ба Г** 97:12). Золиослолоор гэрээнүүдээ сахихад бэлэн байдаг бүх хүмүүс Их Эзэнээр хүлээн зөвшөөрөгддөг, **С ба Г** 97:8. Иосеф Ф. Смит Аврагчийн золиослолтой адил төстэй золиослолыг өргөсөн шударга хүмүүсийн сүнсийг харжээ, **С ба Г** 138:13. Гэтэлгэл нь Бурханы Хүүгийн загалмай дээр золиослолоор дамжин ирсэн бөлгөө, **С ба Г** 138:35.

ЗОРАМ, ЗОРАМЧУУД

Мормоны Номонд, Нифай Лихай нартай нэгдэж амлагдсан нутагт ирсэн Лебений зарц (1 Ниф. 4:31–38). Зорам итгэлтэй байсан учир Лихай түүнийг хөвгүүдийнхээ хамт адисалжээ (2 Ниф. 1:30–32). Түүний үр удам зорамчууд хэмээн нэрлэгддэг байв (Иаков 1:13).

ЗОРИГ, ЗОРИГТОЙ. Итгэл,

Эмээхийг мөн үз

Ялангуяа зөв зүйлийг хийхэд айхгүй байхыг хэлнэ.

Тууштай, зоригтой бай, **Дэд хууль** 31:6 (Иош. 1:6–7). Бичигдсэн бүхнийг сахьж хийхдээ маш тууштай бай, **Иош.** 23:6. Бурхан бидэнд айдсын сүнснийг өгдөггүй, **2 Тим.** 1:7. Тэрээр сонсоод, түүний зүрх зоригжив, **Алма** 15:4 (Алма 62:1). Хиламаны хөвгүүд үлэмж баатарлаг зоригтой байв, **Алма** 53:20–21. Би хэзээ ч тийм агуу их зоригийг үзээгүй, **Алма** 56:45. Зориглогтун, ах дүүс минь тэгээд ялалт өөд ахь, ахь, **С ба Г** 128:22.

ЗОРИУЛАХ, ӨРГӨХ,

ЗОРИУЛЛАГЫН БУЮУ

ӨРГӨЛИЙН ХУУЛЬ. Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс; Нэгдсэн журмыг мөн үз

Зориулах, өргөн барих ариун болгох буюу зөв шударга болох. Зориуллагын хууль нь Бурханы хаант улсыг барихад эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөрсдийн цаг зав, авьяас билиг болон материаллаг зүйлсийг сайн дураараа зориулах буюу өргөл болгох бурханлиг зарчим юм.

Өнөөдөр Их Эзэнд өөрсдийгөө зориул, **Ег.** 32:29. Итгэсэн бүгдэд бүх зүйл нийтийнх байв, **Үйлс** 2:44–45. Тэд өөрсдийн дунд бүх зүйлийг нийтээр эзэмшдэг байв, иймийн тул баян мөн ядуу гэж байсангүй, **4 Ниф.** 1:3. Их Эзэн зориуллагын хуулийг тайлбарлав, **С ба Г** 42:30–39 (**С ба Г** 51:2–19; 58:35–36). Хүн бусаасаа илүүг эзэмших ёсгүй, **С ба Г** 49:20. Гэр бүлийнх нь дагуу хүн

бүрд тэнцүү өгөгдөж байв, **С ба Г** 51:3. Дэг жаяг зохион байгуулагдаж, ингэснээр Гэгээнтнүүд тэнгэрлэг болон дэлхийн зүйлүүдийн үүргүүдэд тэгш байж чадах бууу, **С ба Г** 78:4–5. Хүн бүр эрэлт хэрэгцээнүүд болон хэрэгцээний дагуу өөрийнхөө эрэлт хэрэгцээнд шударга байх ёстой, **С ба Г** 82:17–19. Сион зөвхөн селестиел хуулийн зарчмуудаар баригдаж чадна, **С ба Г** 105:5. Енохын хүмүүс нэг зүрх сэтгэл нэг оюунтай мөн зөв шударга ёсонд амьдарч байлаа, тийнхүү тэдний дунд ядуус байсангүй, **Мосе** 7:18.

ЗОХИСТОЙ, ЗОХИСТОЙ

БАЙДАЛ. Зөв шударга, Зөв шударга ёсыг *мөн үз*

Хувь хүний хувьд зөв шударга байх, Бурханы болон түүний томилсон удирдагчдын мэлмийд сайшаалтай байх.

Загалмайгаа үүрдэггүй тэр нь надад зохистой биш, **Мат.** 10:38. Ажилчид хөлсөө авах нь зохистой, **Лук** 10:7 (**С ба Г** 31:5). Бүх зүйлийг зохистойгоор хийхээ мэд, **Морм.** 9:29. Тэд зохистой биш аваас баптисм хүртэхгүй байсан, **Моро.** 6:1. Залхуу хойрго тэрээр итгэлд зохистой үл тооцогдох авай, **С ба Г** 107:100. Шүүмжлэл үл даах тэрээр миний хаант улсын хувьд зохистой бус бөлгөө, **С ба Г** 136:31. Санваар зохистой бүх эрэгтэй гишүүдэд өгөгдөх болов, **С ба Г** АТ—2.

ЗӨВ ШУДАРГА, ЗӨВ ШУДАРГА

ЁС. Алхах, Бурхантай хамт алхах; Бурханы зарлигууд; Зохистой, Зохистой байдал; Зөв шударга бус байх; Зөв шударга бус явдал; Үнэнч шударга чанарыг *мөн үз*

Үнэнч, ариун, ариун журамтай, цэх шулуун байх; Бурханы зарлигуудад дуулгавартайгаар үйлдэх; нүглээс ангид байх.

Зөв шударга хүнийг ЭЗЭН ерөөх болно, **Дуул.** 5:12. ЭЗЭНий мэлмий

зөв шударга хүн уруу чиглэсэн байдаг, **Дуул.** 34:15, 17 (1 Петр 3:12). Зөв шударга хүн дэвжих тусам ард түмэн баяр жаргалтай байдаг, **Сур.** үгс 29:2 (**С ба Г** 98:9–10). Зөвт байдлын төлөө өлсөж цангагч хүн ерөөлтэй еэ, **Мат.** 5:6 (3 Ниф. 12:6). Бурханы хаант улс болон түүний зөвт байдлыг эхлэд хайгтун, **Мат.** 6:33. Зөвт хүмүүс нь мөнх аминд ордог, **Мат.** 25:46. Зөвт хүний залбирал үр нөлөөтэй, **Иаков** 5:16. Зөв шударга байгч тэрээр Бурханы ээл хишгийг хүртэнэ, **1 Ниф.** 17:35. Зөв шударгыг үйлдэгчдийг тэрээр хамгаалах болно; тэд айх хэрэггүй, **1 Ниф.** 22:17, 22. Их Эзэний хүмүүсийн зөв шударгын улмаас Сатан хүчгүй байх болно, **1 Ниф.** 22:26. Хэрэв зөв шударга гэж үгүй аваас, аз жаргал ч үгүй байх болно, **2 Ниф.** 2:13. Зөв шударгыг үйлдэгчид Бурханы хаант улсыг өвлөх болно, **2 Ниф.** 9:18. Зөв шударгыг үйлдэгчид үнэний үгнээс эмээдэггүй, **2 Ниф.** 9:40. Бүх хүн зөв шударга байдалд орж өөрчлөгдөх ёстой, **Моз.** 27:25–26. Зөв шударгыг үйлдэгчдийн нэрс амьдралын номонд бичигдэх болно, **Алма** 5:58. Та нар алдсыг үйлдэж аз жаргалыг эрэлхийлсэн нь зөв шударга чанарын эсрэг билээ, **Хил.** 13:38. Зөв шударгыг үйлдэгчдийн дуу надад залбирал болдог билээ, **С ба Г** 25:12. Босогтун, зөв шударга ёсны хуягийг өмс, **С ба Г** 27:16 (Ефес 6:14). Зөв шударгыг үйлдэгчдийн үхэл тэдэнд тааламжтай байх болно, **С ба Г** 42:46. Бүх үндэстнүүдийн дундаас зөв шударгыг үйлдэгчид цуглуулагдах болно, **С ба Г** 45:71. Хүмүүс өөрсдийн чөлөөт хүсэл зоригоор туйлын зөв шударга байдлыг тохиолгохоор авчрах ёстой, **С ба Г** 58:27. Зөв шударгын үйлсүүдийг үйлдэх тэрээр энэ дэлхийд амар амгаланг хийгээд ирэх дэлхийд мөнх амьдралыг хүлээн авах болно, **С ба Г** 59:23. Хоёр дахь Ирэлтээр, зөв шударгыг үйлдэгчид хийгээд ёс бусчууд бүрэн салан

тусгаарлагдах нь тохионо, **С ба Г** 63:54. Зөв шударга ёсны зарчмуудаас бусдаар тэнгэрийн тэрхүү хүч нь хянагдаж үл чадна, **С ба Г** 121:36. Зөв шударгыг үйлдэгчдийн дунд амар амгалан байв, **С ба Г** 138:22. СИОНЫ хүмүүс зөв шударга ёсонд оршин сууж байлаа, **Моце** 7:18. Абрахам зөв шударга ёсыг дагагч байв, **Абр** 1:2.

ЗӨВ ШУДАРГА БУС, ЗӨВ

ШУДАРГА БУС ЯВДАЛ. Бузар, Бузар булай явдал; Бурханлиг бус; Ёс бус, Ёс бус явдал; Зөв шударга, Зөв шударга явдал; Нүглийг *мөн үз*

Ёс бус, шударга бус явдал; Бурхан буюу Бурханы зүйлүүдийг хайрладаггүй, түүний зорилгыг дэмждэггүй хүмүүс.

Зөв бус хүмүүс Бурханы хаант улсыг өвлөх нь үгүй, **1 Кор.** 6:9–10. Бузар мууг таалсан хүн яллагдана, **2 Тес.** 2:12. Есүс Христ биднийг зөв бусаас цэвэрлэнэ, **1 Иох.** 1:9. Зөв шударга бус хаан бүх зөв шударгын замуудыг гажуудуулдаг буюу, **Моз.** 29:23. Сүйрлийн суурь нь хуульчид мөн шүүгчдийн шударга бус байдлаар тавигдаж байна, **Алма** 10:27. Зөв шударга бус үйлсийг нь дэлхийд нотлохын тулд би чамайг илгээж байна, **С ба Г** 84:87. Хүн бүх зөв шударга бусаас ариусгагдах ёстой, **С ба Г** 88:17–18. Бараг бүх хүний мөн чанар нь шударга бус эзэгнэлээ хөгжүүлж эхлэх дур сонирхол юм, **С ба Г** 121:39.

ЗӨВЛӨГӨӨ. Бошиглогчийг *мөн үз*

Өөрийнхөө томилсон удирдагчдад Их Эзэнээс өгдөг сануулга, сэрэмжлүүлэг зөвлөмж мөн заавар.

Би чамд зөвлөгөө өгье, **Ег.** 18:19. Бурхан намайг зөвлөгөөгөөрөө удирдана, **Дуул.** 73:24. Зөвлөгөө өгөхгүй бол хүмүүс унана, **Сур.** үгс 11:14. Фарисайчууд болон хуульчид Бурханы зөвлөгөөг үл хэрэгсэв, **Лук** 7:30. Тэд Бурханы зөвлөмжийг дуулах аваас сайн суралцах болно,

2 Ниф. 9:29. Чамайг томилсон түүний зөвлөгөөг сонс, **С ба Г** 78:2. Миний томилсон түүний зөвлөгөөг хүлээн ав, **С ба Г** 108:1. Тэрээр миний томилсон зөвлөлийн оронд өөрийн зөвлөлийг бий болгохыг санаархаж байна, **С ба Г** 124:84. Миний үйлчлэгч Иосефын зөвлөгөөг сонсож дага, **С ба Г** 124:89. Хэрэв аливаа хүн миний зөвлөгөөг хайхгүй бол түүнд хүч байхгүй байх болно, **С ба Г** 136:19.

ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, ЗӨВЛӨГӨӨ

Судруудад хэрэглэгдсэнээр зөвлөх гэдэг нь зөвлөгөө өгөх буюу зааварлах гэсэн утгатай.

Би чамд надаас галд цэвэршүүлсэн алт авахыг зөвлөж байна, **Илч.** 3:18. Их Эзэнд зөвлөхийг бүү эрэлхийл, **Иаков** 4:10. Тэрээр өөрийн бүх бүтээлүүддээ мэргэн ухаанаар зөвлөдөг, **Алма** 37:12. Та нар өөрсдийнхөө замуудад зөвлөгөөг эрэлхийлэх учир та нарын нүглүүд надад ирэх авай, **С ба Г** 56:14.

ЗӨВТГӨЛ, ЗӨВТГӨХ. Ариусгал;

Цагаатгал, Цагаатгахыг *мөн үз*

Нүглийн төлөөх шийтгэлээс уучлагдаж мөн гэмгүй хэмээн мэдэгдэх. Аврагчид итгэх итгэлээр дамжуулан, түүний нигүүлслээр хүн зөвтгөгддөг. Энэхүү итгэл нь наманчлалаар, түүнчлэн сайн мэдээний хуулиуд болон ёслолуудад дуулгавартай байснаар харагддаг. Есүс Христийн цагаатгал нь, наманчлах эсвээс тэдний хүлээн авч болох шийтгэлээс чөлөөлөгдөх буюу уучлагдах боломжийг хүн төрөлхтөнд олгодог.

ЭЗЭНий дотор бүх Израил зөвтгөгдөнө, **Иса.** 45:25. Хуулийг сонсогчид бус, харин хэрэгжүүлэгчид зөвтгөгдөх болно, **Ром** 2:13. Христийн цусаар дамжин хүмүүн зөвтгөгддөг, **Ром** 5:1–2, 9. Та нар ЭЗЭН Есүсийн нэрээр зөвтгөгддөг, **1 Кор.** 6:11. Түүний нигүүлслээр зөвтгөгдсөнөөр бид өв залгамжлагчид болгогдоно, **Тит** 3:7. Бидний эцэг

Абрахам үйлсээрээ зөвтгөгдсөн биш үү? **Иаков** 2:21. Хүмүүн зөвхөн итгэлээр төдийгүй, бас үйлсээрээ зөвтгөгддөг, **Иаков** 2:14–26. Хуулиар зөвтгөгдөх махан бодь гэж үгүй, **2 Ниф.** 2:5. Миний зөв шударга зарц олныг зөвтгөх болно, учир нь тэрээр тэдний алдсуудыг үүрэлцэх болно, **Моз.** 14:11 (Иса. 53:11). Өмсгөлүүд тань Христийн цусаар дамжин цэвэршигдсэн гэж та нар хэлж чадах уу? **Алма** 5:27. Есүс Христийн нигүүлслээр дамжсан зөвтгөл үнэн билээ, **С ба Г** 20:30–31 (С ба Г 88:39). Сүнсээр та нар зөвтгөгддөг, **Моце** 6:60.

ЗӨӨГДСӨН ХҮМҮҮН БИЕС

Үхэшгүй байдалд амилуулагдах хүртлээ өвчин эмгэг, үхлийг үзэхгүй байхаар өөрчлөгдсөн хүмүүс.

Енох Бурхантай хамт явсан; Мөн Бурхан түүнийг авч явсан учир тэрээр байсангүй, **Эхл.** 5:24 (Евр. 11:5; С ба Г 107:48–49). Өнөөг хүртэл Мосегийн булшийг хэн ч мэдэхгүй, **Дэд хууль** 34:5–6 (Алма 45:19). Елиа хуй салхиар тэнгэрт оджээ, **Хаад, дэд** 2:11. Хэрэв би ирэх хүртлээ түүнийг байлгая гэж хүссэн ч, энэ нь чамд ямар хамаа байна? **Иохан** 21:22–23 (С ба Г 7:1–3). Чи хэзээ ч үхлийг амсахгүй, **3 Ниф.** 28:7. Тэд үхлийг амсаж болохгүйн тулд тэдний биесэд өөрчлөлт хийгдсэн ажгуу, **3 Ниф.** 28:38 (4 Ниф. 1:14; Морм. 8:10–11). Хайрт Иохан Их Эзэнийг ирэх хүртэл амьдарна, **С ба Г** 7. Би Енохын Сионыг цээжиндээ аваачсан билээ, **С ба Г** 38:4 (Моце 7:21, 31, 69). Енох болон түүний ахан дүүсийн хот зөв шударгын өдрийг хүртэл хадгалагдан үлдсэн бөлгөө, **С ба Г** 45:12. Елиа үхэл амсалгүйгээр тэнгэрт аваачигдсан ажээ, **С ба Г** 110:13. Ариун Сүнс олны дээр байж тэд тэнгэрийн хүчээр Сионд дээш аваачигдсан болой, **Моце** 7:27.

ЗӨРЧИЛДӨӨН. Эсэргүүцлийг

мөн үз

Маргаан, мэтгэлцээн болон арцалдаан. Тэмцэл, ялангуяа Их Эзэний

Сүмийн гишүүдийн болон гэр бүлийн гишүүдийн хоорондох зөрчилдөөн Их Эзэний таалалд нийцдэггүй.

Чи бид хоёрын хооронд маргаан бүү гараг, **Эхл.** 13:8. Их зан маргаанд хүргэдэг, **Сур. үгс** 13:10. Хэн нэгэнд чинь нөгөөгийнхөө эсрэг гомдол байвал Христ уучилсны адил уучил, **Кол.** 3:13. Мунхаг маргалдаан болон асуултаас зугт, **Тит** 3:9. Их Эзэн хүмүүнд өөр хоорондоо зөрчилдөх ёсгүй хэмээн зарлигладаг, **2 Ниф.** 26:32. Та нар өөрсдийн хүүхдүүдийг нэг нэгэнтэйгээ байлдан мөн тэмцэлдэхийг тэвчихгүй, **Моз.** 4:14. Сүмийн гишүүдийн хооронд зөрчилдөөн байх ёсгүйг зарлиглав, **Моз.** 18:21. Сатан цуурхал болон зөрчилдөөнийг тарааж явав, **Хил.** 16:22. Чөтгөр бол зөрчилдөөний эцэг мөн хүмүүнийг нэг нэгэндээ уурлан зөрчилдөхөд өдөөн хатгадаг билээ, **3 Ниф.** 11:29 (Моз. 23:15). Илүү их зөрчилдөөн байхгүйн тулд миний сайн мэдээг үндэслэн байгуул, **С ба Г** 10:62–64. Нэг нэгэнтэйгээ зөрчилдөхөө зогсоо, **С ба Г** 136:23.

ЗӨРЧИХ, ГОМДООХ, ХАРУУСАЛД ХҮРГЭХ

Тэнгэрлэг хуулийг зөрчих, нүгэл үйлдэх, эсвэл эвгүй байдал буюу эвдрэл, гэмтэлд хүргэх; түүнчлэн гомдоох буюу харуусалд хүргэх.

Гомдсон ах дүүсийг буцааж эргүүлэх нь хүчирхэг хотыг эзлэн авахаас ч илүү хэцүү, **Сур. үгс** 18:19. Хэрэв баруун нүд чинь чамайг бүдрүүлбэл, ухаж аваад хая, **Мат.** 5:29. Хэн надад итгэгч эдгээр багачуудаас нэгийг нь бүдрүүлнэ, түүний хувьд тэнгисийн гүнд живсэн нь дээр, **Мат.** 18:6 (С ба Г 121:19–22). Хэрэв ах буюу эгч чинь чамайг гомдоогоод мөн гэмших аваас чи түүнтэй эвлэрэх ёстой, **С ба Г** 42:88. Түүний мутрыг хүлээн зөвшөөрдөггүй, түүний зарлигуудыг дуулгавартайгаар үл дагах тэднээс бусад хүмүүн Бурханыг юугаар ч гомдоодоггүй, **С ба Г** 59:21.

ЗУУРДЫН. Адам Ева хоёрын
Уналт; Тачаадалт, Тачаангуй;
Эгэл хүнийг *мөн үз*

Ямар нэгэн сүнслэг бус зүйл; ялангуяа энэ үг мөнх бус болон цаг зуурын (С ба Г 67:10) эсвэл дэлхийн, маханбодийн, түүнчлэн тачаангуй шунаг (Моз. 16:10–12) гэсэн утгаар хэрэглэгдэж болдог.

Биеэ бодсон байх нь үхэл, **2 Ниф.** 9:39. Чөтгөр хүмүүнийг зуурдын аюулгүй байдалд тайвшруулдаг, **2 Ниф.** 28:21. Тэд өөрсдийгөө зуурдын байдалд буйгаа төсөөлжээ, **Моз.** 4:2. Өөрийн эгэл чанартаа хэвээрээ үлдсэн тэрээр өөрийн унасан байдалдаа үлддэг, **Моз.** 16:5. Бүгд Бурханаас төрж, өөрсдийн эгэл мөн унасан байдалаасаа өөрчлөгдөх шаардлагатай, **Моз.** 27:25. Хүн төрөлхтөн төрөлхийн эгэл, тачаангуй, чөтгөр мэт болжээ, **Алма** 42:10. Өөрсдийнхөө хүсэл зориг хийгээд төрөлхийн хүслээ дагадаг тэрээр унах ёстой, **С ба Г** 3:4. Хүн төрөлхийн ухаанаараа Бурханыг харж чадахгүй, **С ба Г** 67:10–12. Хүн төрөлхийн эгэл, тачаангуй, мөн чөтгөр лугаа адил болж эхэлсэн ажээ, **Мосе** 5:13; 6:49.

ЗУУТЫН ДАРГА

50-100 хүнтэй хэсгийг захирдаг Ромын цэргийн дарга. Тийм хэсэг Ромын торгон цэргийн зургааны нэгийг бүрдүүлдэг байв. (Мат. 8:5; Лук 23:47; Үйлс 10:1–8-ыг үз.)

ЗУУЧ. Есүс Христ; Цагаатгал,
Цагаатгахыг *мөн үз*

Холбогч буюу зуучлагч. Есүс Христ бол Бурхан ба хүмүүний хоорондын зууч мөн. Түүний цагаатгал нь хүмүүс нүглүүдээсээ наманчилж, Бурхантай эвлэрэх замыг тэдэнд боломжтой болгосон юм.

Хэн ч Есүс Христээр дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй, **Иохан** 14:6. Бурхан ба хүмүүсийн хооронд ганц зууч байна, **1 Тим.** 2:5. Христ бол гэрээний илүү сайн зууч мөн, **Евр.** 8:6

(Евр. 9:15; 12:24; С ба Г 107:19). Ариун Мессиа хүмүүний бүх үрсийг өмгөөлөх болно, **2 Ниф.** 2:9 (Иса. 53:12; Моз. 14:12). Та нар агуу их Зуучид найдах ёстой, **2 Ниф.** 2:27–28. Шинэ гэрээний зууч Есүсээр дамжин бид төгс болгогддог, **С ба Г** 76:69.

ЗҮРХ СЭТГЭЛ. Бурханаас төрөх;
Дахин төрөх; Харууссан
зүрхийг *мөн үз*

Хүний оюун болон хүсэл зоригийн бэлэгдэл, түүнчлэн бүхий л сэтгэл хөдлөл хийгээд бодол санааны зүйрлэсэн эх сурвалж.

Чи өөрийн Бурхан Эзэнийг бүх зүрхээрээ хайрла, **Дэд хууль** 6:5 (Дэд хууль 6:3–7; Мат. 22:37; Лук 10:27; С ба Г 59:5). Эзэн өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуух хүнийг олсон, **1 Сам.** 13:14. Хүн гаднах төрхийг хардаг бол Эзэн зүрхийг нь хардаг, **1 Сам.** 16:7. Цэвэр гартай, ариун зүрхтэй тэр нь Эзэний уул өөд авирч, мөн ерөөгдөх болно, **Дуул.** 24:3–5 (2 Ниф. 25:16). Хүн зүрх сэтгэлдээ боддогтойгоо адил юм, **Сур.** үгс 23:7. Елиа эцгүүдийн зүрхийг хүүхдүүд уруу нь хүүхдүүдийн зүрхийг эцгүүд уруу нь эргүүлднэ, **Малах.** 4:5–6 (Лук 1:17; С ба Г 2:2; 110:14–15; 138:47; ИС—Т 1:39). Зүрхэн дотроо цэвэр ариун байгч хүмүүс ерөөлтэй еэ, **Мат.** 5:8 (3 Ниф. 12:8). Хүн зүрхэн дэх сайн буюу муугаасаа ярьдаг, **Лук** 6:45. Зүрх сэтгэлийнхээ бүрэн зорилгоор Хүүг дагагтун, **2 Ниф.** 31:13. Та нар сүнслэг байдлаараа Бурханаас төрсөн үү? Мөн хүчит өөрчлөлтийг зүрх сэтгэлээрээ эдэлсэн үү?, **Алма** 5:14. Харууссан зүрх гэмшсэн сэтгэлийг Их Эзэнд золиослол болгон өргө, **3 Ниф.** 9:20 (3 Ниф. 12:19; Ифер 4:15; Моро. 6:2). Ариун Сүнсээр оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь би чамд ярих болно, **С ба Г** 8:2.

ЗҮҮД. Илчлэлтийг *мөн үз*

Дэлхий дээрх эрэгтэй, эмэгтэй хүмүүст Бурхан өөрийн тааллыг илчилдэг нэг арга зам. Хэдий тийм

ч, зүүд бүхэн илчлэлт биш. Сүн-сээр өдөөгдсөн зүүд нь итгэлийн үр жимс юм.

Тэрээр зүүдэлж, мөн шат тэнгэрт хүрэхийг болгоов, **Эхл.** 28:12. Иосеф зүүд зүүдлэв, **Эхл.** 37:5. Их Эзэн түүнтэй зүүдэнд ярих болно, **Тоол.** 12:6. Небухаднезар зүүд зүүдэлжээ, **Дан.** 2:1–3. Хөгшин хүн зүүд зүүдлэх болно, **Иоел** 2:28 (Үйлс 2:17). Их Эзэний тэнгэр элч түүний зүүдэнд үзэгджээ, **Мат.** 1:20 (Мат. 2:19). Лихай зүүдэндээ харсан олон зүйлийг бичсэн болой, **1 Ниф.** 1:16. Лихай зүүд зүүдлэв, **1 Ниф.** 8.

ЗҮХЭХ, ЗҮХЛҮҮД. Бүдүүлэг үг хэллэг; Ялыг мөн үг

Судруудад, зүхэл гэдэг нь үндсэн-дээ зөв шударга бус явдлын улмаас ямар нэг юм, хүн буюу хүмүүс дээр эсвэл хүн, юман дээр шүүлтүүд буюу тэдгээрийн үр дагавруудыг авчрахад хүргэдэг бурханлиг хуулийн хэрэглэгдэхүүн үг юм. Зүхлүүд нь Бурханы тэнгэрлэг хайр хийгээд шударга ёсны илрэл юм. Эдгээрийг Бурханаас шууд оноох буюу эсвэл эрх мэдэл бүхий түүний үйлчлэгчид зарлан мэдэгддэг. Заримдаа, зүхлүүдийн бүрэн шалтгааныг зөвхөн Бурхан мэддэг. Түүнээс гадна, Бурханыг санаатайгаар дагадаггүй хүмүүс зүхлийг амсдаг бөгөөд ийм замаар тэд өөрсдийгөө Их Эзэний Сүнэнээс холдуулдаг.

Хувь хүн болон хүмүүс Есүс Христэд итгэх итгэлтэй буюу сайн мэдээний хуулиуд хийгээд ёслолуудад дуулгавартай байвал Их Эзэн зүхлүүдийг зайлуулж болдог (Алма 23:16–18; 3 Ниф. 2:14–16; ИТ 1:3).

Адам Ева хоёрыг мэхэлсэн учир Бурхан могойг хараав, **Эхл.** 3:13–15 (Моце 4:19–21). Адам Ева хоёроос болж газар хараагдсан ажээ, **Эхл.** 3:17–19 (Моце 4:23–25). Абелыг алсан учир Их Эзэн Каиныг хараажээ, **Эхл.** 4:11–16 (Моце 5:22–41). Их Эзэн Каины үр удмыг хараасан, **Эхл.** 9:25–27 (Моце 7:6–8; Абр. 1:21–27). Хэрэв Бурханд дуулгавартай байвал

Израил адислагдах болно, мөн хэрэв дуулгаваргүй байвал хараагдана, **Дэд хууль** 28:1–68 (Дэд хууль 29:18–28). Гехази болон түүний үр удам Нааманы уяман өвчнөөр хараагдав, **Хаад.** дэд 5:20–27. Эртний Израил үндэстнүүдийг аравны нэг болон өргөлөө төлөөгүй тул Их Эзэн хараасан бөлгөө, **Малах.** 3:6–10. Есүс инжрийн модыг зүхэж мөн тэр үхэв, **Марк** 11:11–14, 20–21. Есүс Хоразин, Бетсайд, Капернаум хотуудыг хараав, **Лук** 10:10–15. Леменчүүд Их Эзэнийг сонсоогүй учир тэд Их Эзэний дэргэдээс холдож мөн хараагдсан буюу, **2 Ниф.** 5:20–24. Бүгд Бурханд ирэхээр уригдсан болой, **2 Ниф.** 26:33. Садар самууныг үйлдсэн тэднийг Их Эзэн зүхэх болно, **Иаков.** 2:31–33. Нифайчууд наманчлахгүй аваас леменчүүдээс илүү их зүхлийг хүлээн авна, **Иаков** 3:3–5. Эсэргүүцэгчид өөрсөд дээрээ зүхлүүдийг авчирдаг, **Алма** 3:18–19 (Дэд хууль 11:26–28). Хүмүүсийг Бурханаас зайцуулан удирдсан учир Корихор зүхэгдэв, **Алма** 30:43–60. Хүмүүсийн ёс бусын учир Их Эзэн нифайчуудын газар нутаг болон баялгуудыг зүхэв, **Хил.** 13:22–23 (2 Ниф. 1:7; Алма 37:31). Хилэнцэт жаредчуудыг Их Эзэн зүхсэн бөлгөө, **Ифер** 9:28–35. Христийн цагаатгал бяцхан хүүхдүүдээс Адамын зүхлийг авч хаяв, **Моро.** 8:8–12. Их Эзэнээс нүүр буруулсан тэд зүхэгдсэн билээ, **С ба Г** 41:1. Эцгүүд хийгээд хүүхдүүдийн хооронд гагнагч холбоо эс байх аваас дэлхий зүхлээр цохигдох болно, **С ба Г** 128:18 (Мала. 4:5–6).

Бүдүүлэг үг хэллэг: Зүхэх гэдэг нь мөн бүдүүлэг үг хэллэг, доромжилсон буюу олиггүй зэвүүн үг хэллэг хэрэглэхийг хэлдэг.

Эцэг эхээ хараах ёсгүй, **Ег.** 21:17 (Мат. 15:4). Өөрийгөө захирагчийг бүү хараа, **Ег.** 22:28 (Ном. үгс 10:20). Эрэгтэй эмэгтэй хүмүүс Бурханыг хараах ёсгүй, **Лев.** 24:13–16. Есүсийг мэддэгээ үгүйсгэснээр Петр хараагджээ,

Мат. 26:69–74. Ёс бус нифайчууд Бурханыг зүхэж, мөн үхэхийг хүсч байв, **Морм.** 2:14.

ЗЭМЛЭЛ, ЗЭМЛЭХ.

Бэрхшээлийг мөн үз

Сайжрах болон хүчтэй болоход нь туслахын тулд хувь хүн болон бүлэг хүмүүст өгдөг сахилгын арга хэмжээ буюу залруулга.

Бүхнийг Чадагчийн зэмлэлийг бүү жигш, **Иов.** 5:17 (Сур.үгс 3:11). Өө, Их Эзэн, таны зэмлэдэг хүн ерөөлтэй, **Дуул.** 94:12. Бүх судрууд зэмлэхэд, залруулахаар өгөгдсөн болой, **2 Тим.** 3:16. Их Эзэн хайрладаг хүнээ зэмлэдэг юм, **Евр.** 12:5–11. Их Эзэн өөрийн хүмүүсийг зэмлэх нь зүйд нийцнэ хэмээнэ, **Моз.** 23:21–22. Их Эзэн өөрийн хүмүүсийг зэмлэхээс нааш тэд түүнийг санадаггүй, **Хил.** 12:3. Их Эзэн Жаредын ахтай ярилцан, түүнийг зэмлэжээ, **Ифер** 2:14. Тэд зэмлэгдэж тэд наманчилж болох буюу, **С ба Г** 1:27. Өөрсдийн чинь нүглүүд өршөөгдөхийн тулд өөрийн хайрладаг та нарыг би зэмлэнэ, **С ба Г** 95:1. Зэмлэлийг тэвчдэггүй тэд бүгд ариусгагдаж чадах нь үгүй, **С ба Г** 101:2–5. Тэд дуулгавартай байдлыг сурах хүртлээ миний хүмүүс зэмлэгдэх ёстой нь шаардагдана, **С ба Г** 105:6. Зэмлэлийг үл даах тэрээр миний хаант улсын хувьд зохистой бус бөлгөө, **С ба Г** 136:31.

ИАКОВ, АЛФАЕГИЙН ХҮҮ

Өөрийн мөнх бус тохинууллын үед Есүс Христийн сонгож авсан Арванхоёр төлөөлөгчийн нэг (Мат. 10:3; Марк 3:18; Лук 6:15; Үйлс 1:13).

ИАКОВ, ЗЕБЕДИЙН ХҮҮ

Өөрийн мөнх бус тохинууллын үед Есүс Христийн сонгож авсан Арванхоёр Төлөөлөгчийн нэг. Тэрээр Иоханы дүү байв. Тэр бол зарим тодорхой үйл явдлуудад: Иайрын охиныг босгосон (Марк 5:37). Хувиралт (Мат. 17:1; Марк 9:2;

Лук 9:28) болон Гетсеманид (Мат. 26:37; Марк 14:33) Есүстэй хамт байхаар сонгогдсон гурван Төлөөлөгчийн нэг байлаа. Тэрээр Петр, Иохан хоёртой хамт Иосеф Смитийг томилсноор Мелкизедек санваарыг дэлхийд сэргээжээ (С ба Г 27:12 128:20; ИС—Т 1:72).

ИАКОВ, ИХ ЭЗЭНИЙ ДҮҮ

Шинэ Гэрээнд Их Эзэний (Гал. 1:19) мөн Иосе, Симон, Иудасын мөн эгч нарынхаа дүү нь байжээ (Мат. 13:55–56; Марк 6:3; Иуда 1:1). Мөн тэрээр Шударга Иаков хэмээн нэрлэгдэн, Иерусалим дахь Сүмд чухал албан тушаал хашиж байжээ (Үйлс 12:17; 15:13; 1 Кор. 15:7; Гал. 2:9–12). Тэрээр Иаковын захидлыг бичсэн бололтой.

Иаковын захидал: Шинэ Гэрээний нэг ном. Анх энэ нь гадагш тарагдсан Израилын арванхоёр овогт хандсан захидал байсан бөгөөд Иерусалимаас бичигдсэн бололтой. Уг захидалд ашиг тустай шашны тухай асуудлууд түүний дотор, хэрэв хүнд мэргэн ухаан дутвал тэрээр тусламж хүсч Бурханаас асуух хэрэгтэй (Иаков 1:5–6; ИС—Т 1:9–20) гэсэн бүлэг 1 дэх чухал зөвлөгөө агуулагдсан байдаг. Бүлэг 2 нь итгэл хийгээд ажил үйлсийн тухай өгүүлдэг. Бүлэг 3–4 нь үг хэлээ хянах шаардлага хийгээд бие биенийхээ талаар хилэнцтийг ярихгүй байхыг Гэгээнтнүүдэд сануулсан байдаг. Бүлэг 5 нь тэвчээртэй байхад Гэгээнтнүүдийг урамшуулан, түүнчлэн өвдсөн үедээ адислал авахаар ахлагчдад хандаж байхад нь урамшуулан дэмжсэн байдаг; мөн түүнчлэн уг бүлэг бусдыг хөрвүүлэгдэхэд тусалснаас ирэх адислалуудын тухай сургадаг.

ИАКОВ, ЛИХАЙН ХҮҮ. Нифайн эцэг Лихайг мөн үз

Мормоны Номон дахь нэг бошиглогч бөгөөд 2 Нифайн болон Иаковын номнуудын нилээд хэдэн номлолын зохиогч (2 Ниф. 6–11; Иаков 1–7).

Иаковын ном: Мормоны Номны гурав дахь ном. Бүлэг 1 нь Нифайн цэдгүүдийг Иаковт шилжүүлж өгөн, дараа нь Иаков болон дүү Иосефыг нь санваартнууд хийгээд хүмүүст багш нар байхын тулд адисалсан тухай өгүүлдэг. Бүлэг 2–4 нь ёс суртахууны хувьд цэвэр ариун байхыг хүмүүст сануулсан номлолууд юм. Түүнчлэн Иаков, цагаатгагч Мессаигийн ирэлтийн тухай зааж, мөн Израил дахь зарим хүмүүс түүнийг ирэхэд хүлээн аваагүйн шалтгааныг тэрээр тайлбарлажээ. Бүлэг 5–6 нь Иаковын гэрчлэл болон Израилын хүмүүсийн түүх болон үүргийн тухай бошиглолын ёгтлолыг агуулдаг. Бүлэг 7 нь Иаковын бурханлиг гэрчлэлд ялагдсан Шерем хэмээх эрдэм боловсролтой эсэргүүцэгчийн тухай шастирьг агуулдаг.

ИСААКИЙН ХҮҮ ИАКОВ. Есав;

Израил; Исаакийг *мөн үз*

Хуучин Гэрээний патриарх бөгөөд бошиглогч; Исаак Ребека хоёрын ихэр хөвгүүдийн бага нь (Эхл. 25:19–26). Иаков ах Есавынхаа залгамжлах эрхийг авчээ. Энэ нь Есав залгамжлах эрхээ хөсөрдүүлж, түүнчлэн гэрээнээс гадуур гэрлэсэн байхад Иаков зохистой байж, мөн гэрээний дагуу гэрлэснээс болжээ (Эхл. 25:30–34; 26:34–35; 27; 28:6–9; Евр. 12:16).

Есав Иаковт үйлчлэх болно гэдгийг Ребека Их Эзэнээс мэджээ, **Эхл.** 25:23. Залгамжлах эрхийг Есваас худалдаж авав, **Эхл.** 25:29–34. Тэнгэрт тулсан шат зүүдлэв, **Эхл.** 28. Леа, Рахел нартай гэрлэв, **Эхл.** 29:1–30. Арванхоёр хүү, нэг охинтой болов, **Эхл.** 29:31–30:24; 35:16–20. Билха, Зилпа хоёртой гэрлэв, **Эхл.** 30:3–4, 9. Нэр нь Израил болж өөрчлөгдөв, **Эхл.** 32:28. Бурханыг нүүр тулан харав, **Эхл.** 32:30. Иосефт илүү хайртай байв, **Эхл.** 37:3. Гэр бүлтэйгээ Египет уруу явав, **Эхл.** 46:1–7. Хөвгүүдээ болон тэдний үр удмынхныг адислав, **Эхл.** 49. Нас барав, **Эхл.** 49:33. Зарлигуудыг сахьж, мөн өнөөдөр

Абрахам болон Исаакийн хамт тэнгэрт хаан сэнтийд өргөмжлөгдсөн байгаа билээ, **С ба Г** 132:37.

ИАФЕТ. Ноа, Библийн патриархыг *мөн үз*

Ноагийн ууган хүү, Хуучин Гэрээний бошиглогч (Моце 8:12).

Ноа Иафетыг төрүүлэв, **Эхл.** 5:32 (Эхл. 6:10; Моце 8:12). Иафет болон түүний эхнэр Ноагийн хөвөгч авдарт оров, **Эхл.** 7:13. Иафет хөвөгч авдраас гарав, **Эхл.** 9:18. Бурхан Иафетыг агуу их болгоно, **Эхл.** 9:27.

ИЕЗЕБЕЛ. Ахабыг *мөн үз*

Хуучин Гэрээн дэх Фоеник нутгийн ёс бус эмэгтэй. Тэрээр Елиаг бошиглогч байх үед хаанчилж байсан Израилын хаан Ахабын хатан байв (Хаад. дээд 16:30–31).

Ахабтай Иезебелийн гэрлэсэн нь аливаа бусад үйл явдлаас илүүгээр умард Израилын хаант улсыг унахад хүргэжээ; Иезебел Иеховаг шүтэн бишрэхийн оронд хиймэл шүтээний хамгийн олиггүй хэлбэрүүдийг өөрийн нутгаас авчирч Израилд нэвтрүүлжээ (Хаад. дээд 18:13, 19).

Иезебел Бурханы бошиглогчдоос олныг алав, **Хаад. дээд** 18:4. Иезебел Елиаг алахаар оролдов, **Хаад. дээд** 19:1–3. Иезебелийн ёс бус явдал түүний аймшигт үхлээр дуусав, **Хаад. дэд** 9:30–37.

ИЕРЕМИА. Гашуудлын дууныг *мөн үз*

мэе 626–586 онд Иудейд бошиглож байв, санваартны гэр бүлд төржээ, Хуучин Гэрээний бошиглогч. Агуу их бошиглогчид: Лихай, Езекиел, Хосеа, Даниел нартай ойролцоо үед тэрээр амьдарч байв.

Иеремиа мөнх бус амьдралын өмнөх үед бошиглогч байхаар томилогджээ (Иер. 1:4–5). Тэрээр бошиглогч байсан ойролцоогоор дөчин жилийн туршид Иудей хүмүүсийн

дунд байсан хиймэл шүтээн бишрэх хийгээд ёс суртахуунгүй байдлын эсрэг заадаг байжээ (Иер. 3:1–5; 7:8–10). Байнгын эсэргүүцэл хийгээд доромжлолтой тэрээр тулгарч байв (Иер. 20:2; 36:18–19; 38:4). Иерусалимыг унасны дараа Египет уруу зугтаасан иудей хүмүүс Иеремиаг өөрсөдтэйгөө хамт авч очиход тэнд тэд заншлынхаа дагуу түүнийг чулуугаар шидэж алжээ (Иер. 43:5–6). *Иеремагийн ном*: Бүлэг 1–6 нь Иосиагийн хаанчлалын үед өгөгдсөн бошиглолуудыг агуулдаг. Бүлэг 7–20 нь Иехоиакимын үе дэх бошиглолууд юм. Бүлэг 21–38 нь Зедекиагийн хаанчлалын үеийг өгүүлдэг. Бүлэг 39–44 нь Иерусалимын уналтын дараах бошиглолуудыг агуулж, энэ үеийн түүхэн үйл явдлуудыг дүрслэн харуулдаг. Бүлэг 45 нь хуулийн багш Барукийнх нь амьдрал хамгаалагдах тухай Барукт өгсөн амлалтыг агуулдаг. Эцэст нь бүлэг 46–51 нь харь үндэстнүүдийн талаарх бошиглолууд юм. Бүлэг 52 бол түүхийн дүгнэлт мөн. Иеремиагийн зарим бошиглолууд Нифайн хадгалж үлдээсэн Лебений зэс ялтсууд дээр агуулагдсан байдаг (1 Ниф. 5:10–13). Тэрчлэн Иеремиа Мормоны Номонд өөр хоёр ч удаа дурдагдсан байдаг (1 Ниф. 7:14; Хил. 8:20).

Түүнчлэн Иеремиагийн ном нь мөнх бус байдлын өмнө хүмүүн оршиж байсныг хүлээн зөвшөөрч, Иеремиагийн урьдчилсан томилолт, (Иер. 1:4–5); Израил тараагдалтаасаа эргэж ирэх болон нэг хот буюу Израил Иудей хоёр аюулгүй, амар амгаланд оршин суух газар Сионд хоёр гэр бүл болон цугларах тухай бошиглол (Иер. 3:12–19); түүнчлэн тэднийг олохын тулд олон загасчид анчдыг илгээснээр умардын орнуудаас Израилыг цуглуулах тухай Их Эзэний бошиглолыг агуулдаг (Иер. 16:14–21). Хожмын өдрүүдийн энэхүү үйл явдал нь Мосе Израилыг Египетээс гарган авчирсангай харьцуулахад илүү агуу байх болно (Иер. 16:13–15; 23:8).

ИЕРИХО

Иорданы хөндий дэх, далайн түвшнээс доош 800 фут (245 метр) орших хэрэм бүхий хот. Иерихо бол израилчууд амлагдсан нутагт анх ороход голыг гаталсан тэр газрын ойролцоо байдаг (Иош. 2:1–3; 3:16; 6).

Израилчууд Иерихогийн дэргэд тулалдав, **Иош.** 6:1–20. Иошуа Иерихог зүхэв, **Иош.** 6:26 (Хаад. дээд 16:34). Иерихо Бениаминд оноон өгсөн нутаг дэвсгэрийн дотор байв, **Иош.** 18:11–12, 21. Эзэн сүүлчийн удаа Иерусалим уруу явах замдаа Иериход очив, **Марк** 10:46 (Лук 18:35; 19:1).

ИЕРОБОАМ

Хуучин Гэрээнд Иеробоам хуваагдсан Израилын умард хэсгийн анхны хаан байв. Тэрээр Ефраимын овгийн нэг гишүүн байлаа. Ёс бус Иеробоам Иудагийн угсааны болон Давидын гэр бүлийн эсрэг бослогыг удирджээ.

Дан болон Бетелд хүмүүс шүтэн бишрэхийн тулд хиймэл шүтээнүүдийг Иеробоам бүтээв, **Хаад. дээд** 12:28–29. Ахиа Иеробоамыг буруушаав, **Хаад. дээд** 14:6–16. Иеробоам Израилд бузар нүгэл үйлдсэн хээ төлөө сануулагдсан ажээ, **Хаад. дээд** 15:34 (Хаад. дээд 12:30).

ИЕРУББААЛ. Гидеоныг (Хуучин Гэрээ) мөн үз

Хуучин Гэрээнд, Баалын тахилын ширээг устгасных нь дараа Гидеонд өгсөн нэр (Шүүгч. 6:32; 7:1; 9; 1 Сам. 12:11).

ИЕРУСАЛИМ

Өнөө үеийн Израилд байдаг хот. Библийн түүхэнд энэ хот хамгийн чухал ач холбогдолтой. Христэд итгэгчид, иудейчүүд болон лалын шашинтнуудын хувьд хамгийн ариун зарим газар энэ хотод байдаг бөгөөд итгэлтэй олон сэсгэртнүүд тогтмол ирдэг. Энэ хотыг ариун хот гэх нь олонтаа тохиолддог.

Урьд нэгэн цагт Салем гэгддэг байв (Эхл. 14:18; Дуул. 76:2). Иерусалим, үүнийг нийслэлээ болгосон Давид эзлэн авах хүртэл Иебустын хот байжээ (Иош. 10:1; 15:8; 2 Сам. 5:6–7). Далайн түвшнээс дээш 2600 фут (800 метр) орчимд байдаг энэ хот дараа нь их төлөв уулын боомт болж байлаа. Энэ хот ганцхан хойд талаасаа гүнзгий хөндийнүүдээр хүрээлэгдсэн байдаг.

Иерусалим дахь Хаан Давидын хаанчлалын үед тэрээр модон ордон эзэгнэж байв. Гэвч Соломоны хаанчлалын үед хүмүүс хотыг үзэсгэлэнтэй сайхан болгосон олон зүйлийг хийснээс түүний дотор хааны ордон болон ариун сүм барьсан ажээ.

Израилын болон Иудейн хаант улсууд тусгаарлан салсны дараа, Иерусалим Иудейн нийслэл болсон байна. Энэ хотыг эзлэн түрэмгийлэгч армиуд олон удаа халдан довтолжээ (Хаад. дээд 14:25; Хаад. дэд 14:13; 16:5; 18–19; 24:10; 25). Хезекиагийн үед, Иерусалим шашин шүтлэгийн төв болсон хэдий ч, мээ 320, мээ 168, мөн мээ 65 онуудад нилээд хэсэг нь эвдлэн сүйтгэгдсэн байв. Хотын хэрэм болон ариун сүмийг Херод сэргээн барьсан хэдий ч, мээ 70 онд ромчууд хотыг бүхэлд нь эвдэн сүйтгэжээ.

Мелкизедек Салемын хаан байв, **Эхл.** 14:18 (Евр. 7:2). Исаиа Иерусалимыг гоёмсог өмсгөлүүдээ өмсөхөд уриалан дуудав, **Иса.** 52:1. Их Эзэний үг Иерусалимаас ирэх ёстой байв, **Мика** 4:2. Иерусалимын хувь заяанд Христ гашуудав, **Мат.** 23:37–39 (Лук 13:34). Иерусалим бол амьд Бурханы хот мөн, **Евр.** 12:22. Хэрэв Иерусалим эс нананчлахаа аваас, устгагдах болно, **1 Ниф.** 1:4; 13, 18 (2 Ниф. 1:4; Хил. 8:20). Устгалын дараа Иерусалим оршин суугчдаар дахин эзэмшигдэх болно, **3 Ниф.** 20:46. Иерусалим дахин баригдах болно, **Ифер** 13:5. Христ Иерусалимын адилаар хожмын үед Гэгээнтнүүдийг сэргэмжлүүлэв, **С ба Г** 5:20.

Иудейн тэд Иерусалим уруу зугтан очиг, **С ба Г** 133:13. Их Эзэн Иерусалимаас ярих болно, **С ба Г** 133:21.

ИЕРУСАЛИМ, ШИНЭ. Сион;
Шинэ Иерусалимыг үз

ИЕСС. Давидыг мөн үз

Хуучин Гэрээнд, Давидын эцэг мөн Христийн болон Иудейн бүх хаадын өвөг дээдэс.

Рутын хүү Обед, Иессийн эцэг байв, **Рут** 4:17, 22. Иессийн өвөг дээдэс Иудейд гэдрэг холбогдоно, **Шаст.** дээд 2:5–12 (Мат. 1:5–6).

ИЕТРО. Мосег мөн үз

Хуучин Гэрээний хаанхүү бөгөөд Мосег Египетээс зугтсаны дараа Мосед гэр орон өгсөн Мидианы санваартан. Түүнийг бас Реуел гэдэг (Ег. 2:18). Хожим нь Мосе Иетрогийн охин Зиппоратай гэрлэжээ (Ег. 3:1; 4:18; 18:1–12). Иетро Мосед ажил үүрэг хариуцуулахыг заадаг байв (Ег. 18:13–27). Мосе Мелкизедек санваарыг Иетрогоос хүлээн авчээ (С ба Г 84:6–7).

ИЕХОВА. БИ БАЙДАГ; Есүс
Христийг мөн үз

Израилын Бурханы гэрээний буюу жинхэнэ нэр. Энэ нь “БИ БАЙДАГ нь мөнх” гэсэн утгатай (Ег. 3:14; Иохан 8:58). Иехова бол мөнх бус байдлын өмнөх Есүс Христ бөгөөд Мариагийн хүү болон дэлхийд иржээ (Моз. 3:8; 15:1; 3 Ниф. 15:1–5). Хуучин Гэрээнд Эзэн гэсэн үг гарахад, энэ нь ихэвчлэн Иехова гэсэн утгатай байдаг.

Иехова бол Христ: Эртний бошиглогчид Иеховаг мэддэг байв (Ег. 6:3; Абр. 1:16). Хуучин Гэрээний Иехова бол Христ байсан хэмээн Төлөөлөгч Паул заасан байдаг (Ег. 17:6; 1 Кор. 10:1–4). Мормоны Номонд гардаг Жаредын ах мөнх бус байдлын өмнөх Христийг харж, түүнийг шүтэн биширч байв (Ифер 3:13–15). Түүнчлэн Моронай Христийг Иехова гэсэн байдаг (Моро. 10:34). Кортландын Ариун Сүмд Иосеф Смит,

Оливер Каудери хоёр амилсан Иеховаг харжээ (С ба Г 110:3–4).

ИЕХОШАФАТ

Хуучин Гэрээнд, Иудейн итгэлт хаан (Хаад. дээд 15:24; 22).

ИЖИЛ ХҮЙСТЭНТЭЙГЭЭ

НӨГЦӨХ. Садар самуун;

Тачаадалт; Тачаангуйг *мөн үз*

Ижил хүйстэй хүмүүсийн хоорондох бэлгийн харьцаа. Бурхан энэ төрлийн бэлгийн харилцааг хориглодог.

Тэдэнтэй бид унтаж болохын тулд, тэднийг бидэнд авчрагтун, **Эхл.** 19:1–11 (Мосе 5:51–53). Эр хүн эмэгтэйтэй унтдагийн адил чи эр хүйстэнтэй бүү унт: энэ нь жигшүүрт юм, **Лев.** 18:22 (Лев. 20:13). Израилын хөвгүүдийн дунд янхан эр байх ёсгүй, **Дэд хууль** 23:17. Тэд Содом шиг нүглээ далдлалгүй дэлгэн үзүүлдэг, **Иса.** 3:9 (2 Ниф. 13:9). Эрчүүд нэг нэгэндээ тачаадан тэмүүлэх хүсэлдээ шатжээ, **Ром** 1:27. Ижил хүйстэнтэйгээ нөхцөгчид Бурханы хаант улсыг өвлөхгүй, **1 Кор.** 6:9–10. Хууль нь зөв хүнд зориулагдаагүй харин ижил хүйстэнтэйгээ нөхцөн өөрсдийгөө бузарлагчдаг зориулагдсан байдаг, **1 Тим.** 1:9–10. Өөр гаж махан биеийн араас явдаг тэд мөнхийн галын шийтгэлд өртөхийн жишээ болдог, **Иуда** 1:7.

ИЗРАИЛ. Абрахам — Абрахамын

үр удам; Исаакийн хүү Иаков;

Үрчилж авахыг *мөн үз*

Хуучин Гэрээнд Исаакийн хүү, Абрахамын ач хүү Иаковт Их Эзэн Израил хэмээх нэр өгчээ (**Эхл.** 32:28; 35:10). Израил гэдэг нэр Иаковт өөрт нь болон түүний үр удмынхан эсвээс Хуучин Гэрээнд нэгэн цагт түүний үр удмынхны эзэмшиж байсан хаант улсыг хэлдэг (2 Сам. 1:24; 23:3). Мосе Израилын хүүхдүүдийг Египетийн боолчлолоос удирдан гаргасны дараа (Ег. 3–14) тэднийг шүүгчид гурван зуу гаруй жил захирчээ. Арван овог бослого гарган Рехобоамаас тусгаар үндэс-

тэн бий болгон, Соломоныг нас нөгчих хүртэл Саулаас эхлэн хаад нэгдмэл Израилыг захирч байв. Израилын хаант улс хуваагдсаны дараа, умард овгууд, илүү их том хэсгийн хувьд Израил нэрийг хадгалж үлдсэн байхад өмнөд хаант улс нь Иудей хэмээн нэрлэгддэг байв. Өнөөдөр Канааны нутаг тэрчлэн Израил хэмээн нэрлэгддэг. Өөр нэг утгаар, Израил гэдэг нь Христэд үнэн итгэгч гэсэн үг юм (**Ром** 10:1; 11:7; **Гал.** 6:16; **Еф.** 2:12).

Израилын арванхоёр овог: Нэр нь Израил болон өөрчлөгдсөн Абрахамын ач хүү Иаков арванхоёр хүүтэй байжээ. Тэдний үр удмынхан Израилын арванхоёр овог буюу Израилын хүүхдүүд хэмээгдэх болжээ. Арванхоёр овог нь гэвэл: Реубен, Симеон, Леви, Иуда, Иссахар, мөн Зебулун (Иаков Леа хоёрын хөвгүүд); Дан ба Нафтали (Иаков Билха хоёрын хөвгүүд); Гад ба Ашер (Иаков Зилпа хоёрын хөвгүүд); Иосеф ба Бениамин (Иаков Рахел хоёрын хөвгүүд) (**Эхл.** 29:32–30:24; 35: 16–18).

Иаков нас эцэслэхийнхээ өмнө овгийн удирдагч болгонд адислал өгчээ (**Эхл.** 49:1–28). Дэлгэрэнгүй мэдээллийг Иаковын хөвгүүн бүрийн нэрнээс үз.

Реубен, Иаковын анхны эхнэр Леагаас төрсөн ууган хүү, ёс суртахуунгүй байдлаасаа болж залгамжлах эрхийн адислал хийгээд өв залгамжлалаа давхар алджээ (**Эхл.** 49:3–4). Залгамжлах эрх нь тийнхүү Иаковын хоёр дахь эхнэр Рахелын ууган хүү асан Иосефт шилжсэн ажээ (Шаст. дээд 5:1–2). Их Эзэн өөрийн санваарын тохинуулалд үйлчлүүлэхээр овгийг нь сонгож авсан Леви бүх овгуудын дунд тохинуулах тусгай дуудлагынхаа улмаас өв хүлээн авсангүй. Энэ нь Израилын тусгаар овгууд (ИСО, **Эхл.** 48:5–6) хэмээн тооцогдож байсан Иосефын хөвгүүд Ефраим болон Манассетай давхар хувийг хуваалцах боломжийг Иосефт олгожээ (Шаст. дээд 5:1; **Иер.** 31:9)

Иудейн овгийн гишүүд Мессаиг ирэх хүртэл захирагчид байх ёстой байв (Эхл. 49:10; ИСО, Эхл. 50:24). Хожмын өдрүүдэд Ефраимын овог сайн мэдээний сэргээлтийг дэлхийд авчрах болон тараагдсан Израилыг цуглуулах үйл хэрэгт онцгой үүрэг гүйцэтгэх болно (Дэд хууль 33:13–17). Есүс Христийн сайн мэдээгээр дамжуулан, Ефраим Израилын бүх овгуудыг нэгтгэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх цаг ирэх болно (Иса. 11:12–13; С ба Г 133:26–34).

Израилын тараагдалт: Зөв шударга бус байдал хийгээд эсэргүүцлийнх нь улмаас Их Эзэн Израилын арванхоёр овгийг тарааж, зовлонд учруулсан билээ. Гэсэн ч Их Эзэн өөрийн сонгосон хүмүүсийг дэлхийн үндэстнүүдийн дунд тараасан энэхүү тараалтыг тэдгээр үндэстнүүдийг адислахад бас ашигласан ажээ.

Та нарыг Би үндэстнүүдийн дунд тараах болно, **Лев.** 26:33. Эзэн та нарыг бүх хүмүүсийн дунд тараах болно, **Дэд хууль** 28:25, 37, 64. Би тэднийг дэлхийн бүх хаант улсуудаар хэрэн тэнэх болгоно, **Иер.** 29:18–19. Израилын угсааг би үндэстнүүдийн дунд шигших болно, **Амос** 9:9 (Зех. 10:9). Есүс Израилын угсааны алдагдсан хонинд илгээгдсэн билээ, **Мат.** 15:24. Энэ сүргийнх биш өөр хоньд надад бий, **Иохан** 10:16. Израил дэлхийн бүх гадаргуу дээр тараагдах болно, **1 Ниф.** 22:3–8. Иаков таримал болон зэрлэг чидуны моддын тухай Зиносын ёгтлолыг иш татав, **Иаков** 5–6. Эцэгийн ажил төөрөлдсөн овгуудын дунд эхлэх болно, **3 Ниф.** 21:26.

Израилын цугларалт: Израилын угсаа хожмын өдрүүдэд Христийн ирэлтийн өмнө цуглуулагдах болно (ИТ 1:10). Өөрийг нь хүлээн авч, түүнчлэн зарлигуудыг нь сахьсан үед Их Эзэн өөрийн хүмүүс Израилыг цуглуулна.

Тэр туг өргөж мөн тэд ирэх болно, **Иса.** 5:26. Би чамайг агуу нигүүлсээр цуглуулна, **Иса.** 54:7. Израил

болон Иудей өөрсдийнхөө нутагт цуглуулагдах болно, **Иер.** 30:3. Тэдний тараагдсан хүмүүсийнх нь дундаас Их Эзэн Израилын угсааг цуглуулах болно, **Езек.** 28:25. Цаг хугацааны бүрэн байдлын эрин үед тэрээр бүх зүйлийг Христэд нэг болгон цуглуулах болно, **Еф.** 1:10. Израил тараагдсаны дараа тэд цуглуулагдах болно, **1 Ниф.** 15:12–17. Их Эзэн Израилын угсааны бүх хүмүүсийг цуглуулах болно, **1 Ниф.** 19:16 (3 Ниф. 16:5). Тэд харанхуйгаас гарган авчрагдаж мөн Их Эзэн бол өөрсдийнх нь Аврагч гэдгийг мэдэх болно, **1 Ниф.** 22:12. Бурхан хүүхдүүдээ цуглуулж мөн тоолдог, **1 Ниф.** 22:25. Харийнханы үндэстнүүд Израилыг өвийнх нь нутгуудад урагш авчрах болно, **2 Ниф.** 10:8 (3 Ниф. 16:4). Миний хүмүүс хийгээд миний үг нэг болж цугларах болно, **2 Ниф.** 29:13–14. Ахлагчид сонгогдсон хүмүүсийг цуглуулахаар дуудагдсан буюу, **С ба Г** 29:7 (С ба Г 39:11). Би өөрийн сонгосон хүмүүсийг цуглуулах болно, **С ба Г** 33:6. Би та нарт өөрийн хуулийг өгч болохын тулд, та нар хишиг хүртээгдэж болохын тулд цугларатун, **С ба Г** 38:31–33. Израилын угсаа болох өөрийн хүмүүсийг би дахин сэргээх болно, **С ба Г** 39:11. Гэгээнтнүүд урагш гарч ирэх болно, **С ба Г** 45:46. Цугларалтын түлхүүрүүдийг Мосе өгөв, **С ба Г** 110:11. Зөв шударга ёс хийгээд үнэн нь газар дэлхийг шүүрдэж, Их Эзэний сонгосон хүмүүсийг цуглуулах болно, **Мосе** 7:62. Цугларалт нь бүргэд хүүрэн дээр цугларахтай харьцуулагджээ, **ИС—Мат.** 1:27.

Израилын алдагдсан арван овог: Израилын арван овог нь умард Израилын хаант улсыг бүрдүүлж байсан бөгөөд мээ 721 онд Ассирид боолчлолд аваачигджээ. Тэр үед тэд “умардын орнууд” уруу явж, бусдад үл мэдэгдэх байдлаар алга болжээ. Эцсийн өдрүүдэд тэд эргэж ирэх болно.

Би умардад хандан, Тэднийг гаргаж

өг хэмээн хэлэх болно, **Иса.** 43:6. Эд нар умардаас ирэх болно, **Иса.** 49:12 (1 Ниф. 21:12). Иудей болон Израил умардын нутгаас хамтдаа гарч ирэх болно, **Иер.** 3:18. Умардын нутгаас Израилын хүүхдүүдийг авчирсан Эзэн амьдардаг, **Иер.** 16:14–16. Би тэднийг умардын орноос авчрах болно, **Иер.** 31:8. Нифайчууд болон иудейчүүдэд Израилын алдагдсан овгуудын үгс байх болно, **2 Ниф.** 29:12–13. Израилын төөрөлдсөн овгуудад би өөрийгөө үзүүлэхээр явлаа, **3 Ниф.** 17:4. Сайн мэдээ Израилын угсааны үлдэгдэлд номлоход төөрөлдсөн овгууд өвийнхөө нутагт гэр орондоо цуглуулагдах болно, **3 Ниф.** 21:26–29. Израилын цугларалтын түлхүүрүүдийг Мосе Иосеф Смит, Оливер Каудери хоёрт даатгав, **С ба Г** 110:11. Умардын орнуудад буй тэд Их Эзэний өмнө дурсамжид ирэх болно, **С ба Г** 133:26–32. Израил жинхэнэ ёсоор цугларна гэдэгт бид итгэдэг, **ИТ** 1:10.

ИЗРАИЛЫН АРВАНХОЁР ОВОГ.

Израил—Израилын Арванхоёр овгийг үз

ИЗРАИЛЫН АРИУН НЭГЭН.

Есүс Христийг үз

ИЗРАИЛЫН ТАРААГДАЛТ.

Израил—Израилын тараагдалтыг үз

ИЗРАИЛЫН УГСАА. Израилыг үз

ИЗРАИЛЫН ХҮҮХДҮҮД.

Израилыг үз

ИЗРАИЛЫН ЦУГЛАРАЛТ.

Израил—Израилын цугларалтыг үз

ИЛЧЛЭЛТ. Ариун Сүнс;

Бошиглол, Бошиглох;
Бурханлиг нөлөө, Бурханлигаар нөлөөлөх; Бурханы Үг; Гэрэл; Христийн гэрэл; Дуу хоолой; Зүүд; Үзэгдлийг мөн үз

Бурханаас дэлхий дээрх хүүхдүүдтэйгээ харилцах явдал. Илчлэлт нь Христийн гэрэл ба Ариун Сүнсээр

дамжин сүнсний нөлөөллийн аргаар үзэгдлүүд, зүүд буюу тэнгэр элчүүдийн айлчлалаар ирдэг. Илчлэлт нь итгэлтнүүдийг селестиел хаант улс дахь мөнхийн аврал уруу хөтөлдөг удирдамжаар хангадаг.

Их Эзэн өөрийн ажлыг бошиглогчиддоо илчилж, бошиглогчиддоог өгсөн эдгээр илчлэлтүүд үнэн гэдгийг итгэгчдэд нотолдог (Амос 3:7). Удирдамж хүссэн бөгөөд итгэлтэй, наманчилдаг түүнчлэн Есүс Христийн сайн мэдээнд дуулгавартай байдаг хүн болгоныг Их Эзэн илчлэлтээр дамжуулан нэг бүрчлэн удирдамжаар хангадаг. Ариун Сүнс бол илчлэгч мөн илчлэлт хүлээн авахгүйгээр хүн Ариун Сүнсийг хүлээн авч чадахгүй хэмээн Иосеф Смит хэлжээ.

Их Эзэний Сүм дэх Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга нь Сүмд хийгээд дэлхийд бошиглогчид үзмэрчид, мөн илчлэгчид юм. Сүмийн ерөнхийлөгч бол Сүмд зориулсан илчлэлтийг хүлээн авахаар Их Эзэнээс эрх мэдэл олгосон цорын ганц хүн мөн (С ба Г 28:2–7). Хүн болгон өөрийн ашиг тусын тулд хувиараа илчлэлт хүлээн авч болно.

ЭЗЭНий амнаас гарах үг бүрээр хүн амьдардаг, **Дэд хууль** 8:3 (Мат. 4:4; С ба Г 98:11). ЭЗЭН намуухан хүнгэнэсэн дуугаар ярьдаг, **Хаад. дээд** 19:12. Алсын хараа байхгүй бол ард түмэн дэг журамгүй байна, **Сур. үгс** 29:18. Үнэхээр Эзэн Бурхан зарц нар, эш үзүүлэгчиддээ Өөрийн нууцыг илчлэхээс нааш Тэр юуг ч хийхгүй, **Амос** 3:7. Симон Барион аа, чи ерөөлтэй еэ! Учир нь үүнийг чамд мах цус биш, харин миний Эцэг илчилсэн юм, **Мат.** 16:15–19. Сүнс та нарыг бүх үнэн уруу удирдаж мөн ирэх зүйлүүдийг та нарт үзүүлэх болно, **Иохан** 16:13. Та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, тэрээр Бурханаас асууг, **Иаков** 1:5. Бүх зүйл илчлэгдэх болно, **2 Ниф.** 27:11. Би хүмүүний үрст шат шатаар өгөх болно, **2 Ниф.** 28:30. Илчлэгдсэн

байхаас гадуур нууц гэж үгүй, **2 Ниф.** 30:17. Ариун Сүнс та нарт бүх зүйлийг үзүүлэх болно, **2 Ниф.** 32:5. Хүмүүнд илчлэгдээгүй аваас хэн ч түүний замуудыг үл мэднэ, **Иаков** 4:8. Илчлэлтийн төлөө Алма мацаг барьж мөн залбирав, **Алма** 5:46. Хэзээ ч илчлэгдээгүй зүйлүүд итгэлтнүүдэд илчлэгдэх болно, **Алма** 26:22. Илчлэлтийг үгүйсгэдэг хүмүүс Есүс Христийн сайн мэдээг мэдэхгүй бөгөөд судруудыг ойлгох нь үгүй, **Морм.** 9:7–8. Итгэлийн чинь сорилтын дарааг хүртэл та нар гэрчийг үл хүлээн авах болой, **Ифер** 12:6. Миний үг бүгд биелэгдэх болно, **С ба Г** 1:38. Энэ асуудлын талаар би амар амгаланг та нарын оюунд яриагүй гэж үү? **С ба Г** 6:22–23. Би та нарын оюунд мөн та нарын зүрх сэтгэлд ярих болно, **С ба Г** 8:2–3. Энэ зөв аваас цээжин биеийг чинь шатахаар болгоно би, **С ба Г** 9:8. Илчлэлтийн сүнсийг бүү үгүйсгэ, **С ба Г** 11:25. Асуудаг хүмүүс илчлэлтийг илчлэлт дээр хүлээн авах болно, **С ба Г** 42:61. Ариун Сүнсээр урагш хөдөлгөгдөх тэд юуг ч ярилаа гэсэн Их Эзэний дуу хоолой байх ёстой, **С ба Г** 68:4. Бурхан та нарт мэдлэг өгөх болно, **С ба Г** 121:26. Иосеф Смит Эцэг, Хүү хоёрыг харав, **ИС—Т** 1:17. Бурхан илчилсэн мөн цаашид илчлэх бүхэнд бид итгэдэг, **ИТ** 1:7, 9.

ИММАНУЕЛ. Есүс Христийг

мөн үз

Есүс Христийн нэг нэр. Энэ нь еврей хэлний Бурхан бидэнтэй хамт гэсэн үгнээс гаралтай ажээ.

Иммануел бол Бурханы чөлөөлөлтийн тэмдэг болон өгөгдсөн нэр юм (Иса. 7:14). Иммануелыг Исаиа иш татсаныг Есүс мөнх бус амьдралд төрөх тухай бошиглол болгон Матай онцлон тэмдэглэсэн байдаг (Мат. 1:18–25). Уг нэр түүнчлэн хожмын үеийн сударт гардаг (2 Ниф. 17:14; 2 Ниф. 18:8; С ба Г 128:22).

ИНОС, ИАКОВЫН ХҮҮ

Залбирч мөн Христэд итгэх итгэлээ-

рээ дамжуулан нүглүүдийнхээ ангижралыг хүлээж авсан нифайчуудын бошиглогч хийгээд Мормоны Номон дахь цэдэг хөтлөгч (Инос 1:1–8). Мормоны Номыг леменчүүдэд авчрах тухай Их Эзэн Иностой гэрээ байгуулжээ (Инос 1:15–17).

Иносын ном: Өөрийнхөө төлөө, өөрийн хүмүүсийн болон бусдын төлөө өршөөл гуйж Инос залбирсан тухай өгүүлдэг, Мормоны Номон доторх нэг ном. Мормоны Ном хадгалагдан үлдэж, ирээдүйд леменчүүдэд очих тухай Их Эзэн түүнд амлажээ. Хэдийгээр уг ном ганцхан бүлэгтэй ч гэсэн, Бурханы зарлигуудад дуулгавартай амьдарч, мөн нас барахынхаа өмнө Гэтэлгэгчийн тухай мэдлэгт баяссан хүний тухай хүчирхэг өгүүллийг агуулдаг билээ.

ИОВ

Хуучин Гэрээнд, туйлын хэцүү зовлон зүдгүүр амссан хэдий ч Бурханд итгэх итгэлтэй хэвээрээ үлдсэн зөв шударга хүн. Түүний түүх Иовын номонд өгүүлэгддэг.

Иовын ном: Уг ном хэдийгээр Иовын зовлонгийн тухай ч гэсэн, Иов (эсвэл аливаа бусад хүн) яагаад зовлон зүдгүүр амсаж, түүнчлэн гэр бүл, өмч хөрөнгөө алдав гэдэг асуултад бүхэлд нь хариулдаггүй. Гай зовлон үзэх нь тухайн хүн заавал нүгэл үйлдсэн байна гэсэн хэрэг биш гэдгийг уг ном тодруулан тайлбарладаг. Их Эзэн зовлон зүдгүүрийг туршлага суулгах, сахилгажуулах, заавар өгөх хийгээд түүнчлэн шийтгэлийн учир ашиглаж болдог (С ба Г 122).

Номыг дөрвөн хэсэгт хувааж болно. Бүлэг 1–2 нь уг өгүүллийн эхлэл юм. Бүлэг 3–31 нь Иов болон түүний гурван найзын хоорондох цуврал яриануудыг өгүүлдэг. Бүлэг 32–37 нь эхний гурван найзынхаас өөр шалтгааны учир Иовыг зэмлэсэн дөрөв дэх найз Элихугийн яриануудыг агуулдаг. Бүлэг 38–42 нь түүний амьдралын замнал эхлэлээс сайн

байсан хэмээх баттай итгэлийг Иовт төрүүлэн номыг төгсгөдөг.

Хэрэв хүн Бурханы тухай зөв мэдлэгтэй байж, Бурхан хүлээн зөвшөөрөхүйц амьдралаар амьдрах юм бол, өөр дээрээ ирэх зовлон задгүүрийг хулцэн тэвчих илүү чадвартай байх болно гэдгийг Иовын ном заадаг. Иовын бөхөшгүй итгэл нь тэр намайг аллаа ч гэсэн би түүнд итгэсэн хэвээр байх болно гэхчлэнгийн мэдэгдлүүдээр тодорхойлогддог (Иов 13:15). Түүнчлэн Езекиел 14:14; Иаков 5:11; Сургаал ба Гэрээ 121:10-т Иов дурдагддаг.

ИОЕЛ

Хуучин Гэрээн дэх Иудей нутгийн бошиглогч. Түүний амьдарч байсан үе тодорхойгүй бөгөөд тэрээр мээ 850 оноос өмнө, түүнчлэн Иудагийн овог Вавилон дахь боолчлолоос эргэж ирсний хоорондох Иоашийн хаанчлалын үед амьдарч байсан бололтой.

Иоелын ном: Иудейн нутаг их ган болон царцаанд нэрвэгдсэний дараа Иоелын хийсэн бошиглол дээр энэ ном төвлөрдөг (Иоел 1:4–20). Наманчлалаар дамжуулан тэд Бурханы адислалуудыг дахин хүлээн авна гэдэгт Иоел хүмүүсийг итгүүлж байжээ (Иоел 2:12–14).

Бүлэг 1 нь Их Эзэний өргөөнд хүндэтгэлтэйгээр чуулахыг уриалан дууддаг. Бүлэг 2 нь Мянганы өмнөх дайн хийгээд үгүйрлийн тухай өгүүлдэг. Бүлэг 3 нь хожмын өдрүүдийн тухай өгүүлж, бүх үндэстнүүд дайн тулаанд байх боловч эцсийн эцэст Их Эзэн Сионд оршин суух болно гэдгийг нотолдог.

Пентекостын өдөр дээр Сүнс цутгагдах тухай Иоелын бошиглолыг Петр иш татсан байдаг (Иоел 2:28–32; Үйлс 2:16–21). Тэнгэр элч Моронай бас яг энэ хэсгийг Иосеф Смитэд иш татан хэлсэн байдаг (ИС—Т 1:41).

ИОНА. Ниневег *мөн үз*

Ниневе хотод наманчлалыг ном-

лохоор Их Эзэнээр дуудагдсан Хуучин Гэрээний нэг бошиглогч (Иона 1:1–2).

Ионагийн ном: Ионагийн амьдралын туршлагын тухай өгүүлдэг, Хуучин Гэрээний нэг ном. Номыг Иона өөрөө бичээгүй бололтой. Ионагийн номны гол үзэл санаа нь Иехова газар сайгүй хаанчилдаг бөгөөд аль нэг ганцхан үндэстэн буюу хүмүүст хайраа харуулдаггүй явдал мөн.

Бүлэг 1-д Их Эзэн Ионаг Ниневед номлохоор дуудсан байдаг. Иона Их Эзэний зарлигласныг хийхийн оронд завиар зугтаж, аварга том загас түүнийг залгижээ. Бүлэг 2-т Иона Их Эзэнд залбирахад загас Ионаг хуурай газарт бөөлжин гаргадаг. Бүлэг 3 нь Иона Ниневед очиж уг хотын уналтын тухай бошиглодог. Гэсэн ч хүмүүс наманчилжээ. Бүлэг 4-т Их Эзэний аварсан хүмүүст уурласных нь төлөө Их Эзэн Ионаг зэмлэдэг.

Загасанд залгиулсан Ионагийн бие нь Есүсийн өөрийнх нь үхэл хийгээд амилалтыг угтан харуулсныг Есүс заасан байдаг (Мат. 12:39–40; 16:4; Лук 11:29–30).

ИОНАТАН. Давид; Израилын хаан Саулыг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Израилын хаан Саулын хүү. Ионатан Давидын дотнын найз байв (1 Сам: 13–23, 31).

ИОРДАН ГОЛ

Иордан гол Галилын тэнгисээс Сөнөсөн тэнгист цутгадаг. Гол нэг зуун миль (160 километр) урт бөгөөд Хермон уулнаас эх авсан нилээд хэдэн горхи нийлснээр бий болдог. Энэ бол Израилын хамгийн чухал гол юм.

Энэ голтой холбоотой хоёр чухал үйл явдал гэвэл Их Эзэн Израилаар хөндлөн гулд зорчихын тулд энэ голыг гаталдаг байсан (Иош. 3:14–17), түүнчлэн Есүс Христ баптисм хүртсэн явдал мөн (Мат. 3:13–17; 1 Ниф. 10:9).

ИОСЕФ, ИАКОВЫН ХҮҮ. Израил;
Исаакийн хүү Иаковыг *мөн үз*

Хуучин Гэрээн дэх Иаков Рахел хоёрын ууган хүү (Эхл. 30:22–24; 37:3).

Иаковын анхны эхнэрийн ууган хүү Реубен зөрчлийн улмаас давуу эрхээ алдсан учир Израил дахь залгамжлах эрхийг Иосеф авчээ (Шаст. дээд 5:1–2). Иаковын хоёр дахь эхнэрийн ууган хүү Иосеф зохистой байсан учраас, адислалын шугамд дараачийнх нь байв. Үүнчлэн Иосеф Иаковыг нас барахын өмнөхөн эцгээсээ адислал хүлээн авчээ (Эхл. 49:22–26).

Иосеф бол агуу зан төлөв бүхий “цэцэн мэргэн ухаантай” (Эхл. 41:39) хүн байв. Тэрээр Потифарын эхнэрт няцаалт өгсөн нь итгэл, ариун явдал хийгээд хувь хүний ёс суртахууны эрхэм чанарын үлгэр жишээ мөн (Эхл. 39:7–12). Египетэд Иосеф ах нартаа өөрийгөө зөвөөр таниулж тэд түүнд хэрхэн хандаж байсных нь төлөө тэднийг ичээхийн оронд тэрээр талархал илэрхийлжээ. Тэдний үйл ажиллагаа Бурханы тэнгэрлэг тааллыг гүйцэлдүүлэхэд тусалсанд тэрээр итгэсэн байв (Эхл. 45:4–15).

Хожмын өдрүүд дэх Иосефын гэр бүлийн илүү том үүргийг хожмын үеийн илчлэлт илэрхийлсэн байдаг (2 Ниф. 3:3–24; 3 Ниф. 20:25–27; ИСО, Эхл. 50).

Иаков Иосефыг ихэд хайрлаж, түүнд олон өнгийн тансаг дээл хийж өгчээ, Эхл. 37:3. Атаархлын улмаас Иосефын ах нар түүнд дургүй болж өссөн бөгөөд түүнийг алахаар хуйвалдаж байсан боловч Египет уруу явж байсан жинчдэд түүнийг худалджээ, Эхл. 37:5–36. Египетэд Их Эзэн Иосефыг цэцэглэн хөгжүүлж, ийнхүү тэрээр Потифарын гэрийн захирагч болов, Эхл. 39:1–4. Иосеф өөрт нь сээтэн хаях гэсэн хэмээн Потифарын эхнэр худал хэлэв; Иосеф хилсээр зэмлэгдэж, шоронд хоригдов, Эхл. 39:7–20. Фараоны ахлах сөнч бөгөөд

талхчны зүүдийг Иосеф тайлав, Эхл. 40. Фараогийн нэг зүүдийг Иосеф тайлсны учир Фарао Иосефт сайн болов; тэрээр Иосефыг Египетийн захирагч болгов, Эхл. 41:14–45. Ефраим, Манассе нар төрөв, Эхл. 41:50–52. Иосеф эцэг, ах нартайгаа дахин нэгдэв, Эхл. 45–46. Иосеф 110 настайдаа Египетэд өөд болов, Эхл. 50:22–26.

ИОСЕФ, МАРИАГИЙН НӨХӨР.

Есүс Христ, Есүсийн эх Мариаг *мөн үз*

Есүсийн эх Мариагийн нөхөр. Иосеф бол Давидын удмын хүн (Мат. 1:1–16; Лук 3:23–38). Назарт амьдарч байв. Тэрээр Мариатай гэрлэв. Тэдний гэрлэлтийн өмнөхөн Мариа Аврагчийн эх байхаар сонгогдсон тухай мэдэгдсэн тэнгэр элч Габриел түүнд айлчилжээ (Лук 1:26–35). Иосеф түүнчлэн энэхүү бурханлиг төрөлтийн тухай илчлэлтийг хүлээн авчээ (Мат. 1:20–25).

Бурхан Эцэг Есүсийн эцэг байсан учраас Мариа л зөвхөн Есүсийн дэлхийн эх билээ. Гэвч иудейчүүд Иосефыг Есүсийн эцэг гэж бодон, мөн Есүс ч түүнд ийм байдлаар ханддаг байв (Лук 2:48, 51). Тэнгэрлэг зүүдээр сэрэмжлүүлэгдэн Иосеф Египет уруу зугтсанаар нялх Есүсийг хамгаалж чаджээ (Мат. 2:13–14). Херодыг нас барсны дараа нэг тэнгэр элч Христ хүүг Израилд буцааж аваачихыг Иосефт зааварлажээ (Мат. 2:19–23).

ИОСЕФ СМИТ (АХМАД). Смит

Иосеф (Бага); Смит Люси
Макийг *мөн үз*

Бошиглогч Иосеф Смитийн эцэг. Тэрээр 1771 оны долдугаар сарын 12-нд төржээ. Тэрээр Люси Мактай гэрлэж тэд есөн хүүхэдтэй болжээ (ИС—Т 1:4). Иосеф хожмын үеийн сэргээлтийн итгэлтэй итгэгч мөн Сүмийн анхны патриарх байв. Тэрээр 1840 оны есдүгээр сарын 14-нд нас баржээ.

Хүү Иосефоор нь дамжуулан Бурхан түүнд зааврууд илчилжээ, **С ба Г 4, 23:5**. Миний настай үйлчлэгч Иосеф гэр бүлийнхээ хамт үргэлжлүүлэг, **С ба Г 90:20**. Миний настай үйлчлэгч Иосеф Абрахамтай хамт түүний баруун гар талд суух болой, **С ба Г 124:19**. Бага Иосеф Смит өөрийнх нь эцэгийг селестиел хаант улсад байгаа үзэгдлийг харжээ, **С ба Г 137:5**. Тэнгэр элч Бага Иосеф Смитийг өөрийнхөө хүлээн авсан үзэгдлийг эцэгтээ хэлэхийг зарлиглажээ, **ИС—Т 1:49–50**.

ИОСЕФ СМИТ (БАГА). Агуу Үнэт Сувд; Анхны үзэгдэл; Иосеф Смитийн Орчуулга (ИСО); Мормоны Ном; Сайн мэдээний сэргээлт; Сургаал ба Гэрээг мөн үз

Дэлхий дээр Есүс Христийн үнэн Сүмийг сэргээхээр сонгогдсон бошиглогч. Иосеф Смит Америкийн Нэгдсэн Улсын Вермонт мужид төрсөн бөгөөд 1805–1844 оныг хүртэл амьдарчээ.

1820 онд Бурхан Эцэг Есүс Христ хоёр Иосеф дээр хүрч ирэн мөн тэрээр дэлхий дээрх сүмүүдийн аль нь ч үнэн биш болохыг мэдэж авчээ (ИС—Т 1:1–20). Америк тивийн эртний хүмүүсийн цэдгийг агуулсан алтан ялтсуудыг нуусан газрыг илчилсэн тэнгэр элч Моронай түүн дээр хожим нь иржээ (ИС—Т 1:29–54).

Иосеф алтан ялтсуудыг орчуулж, 1830 онд Мормоны Ном хэмээн нэрлэж нийтэлсэн билээ (ИС—Т 1:66–67, 75). 1829 онд тэрээр санваарын эрх мэдлийг Иохан Баптист, Петр, Иаков, Иохан нараас хүлээн авчээ (С ба Г 13; 27:12; 128:20; ИС—Т 1:68–70).

Бурханы чиглүүлснээр, 1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд Иосеф хийгээд өөр хэдэн хүмүүс Есүс Христийн Сүмийг сэргээжээ (С ба Г 20:1–4). Иосефын удирдлаган дор Сүм Канад, Англи хийгээд Нэгдсэн Улсын дорнод хэсэг, ялангуяа Огайо, Миссури, Иллинойд хөгжсөн

байв. Иосеф болон Гэгээнтнүүдийн суурьшсан газар бүрд тэднийг ноцтой хавчлагууд дагалдав. 1844 оны зургадугаар сарын 27-нд Иосеф түүний ах Хайрум хоёр Америкийн Нэгдсэн Улсын Иллинойн Картейжид алагджээ.

Иаковын хүү Иосеф нь Иосеф Смитийн талаар бошиглов, **2 Ниф. 3:6–15**. Ойртож буй устгалын тухай тэрээр мэдэж байсан учир Их Эзэн өөрийн үйлчлэгч Иосеф Смитийг дууджээ, **С ба Г 1:17** (С ба Г 19:13). Иосеф Смит Есүс Христийн Төлөөлөгч хийгээд энэ Сүмийн анхны ахлагчаар томилогдов, **С ба Г 20:2**. Иосеф төлөөлөгчийн албанд Петр, Иаков, болон Иоханаар томилогдов, **С ба Г 27:12**. Иосеф Сидней Ригдон нар Эцэгийн Төрсөн Ганцыг харсан хэмээн гэрчлэв, **С ба Г 76:23**. Иосеф Смит, Оливер Каудерийн хамт Их Эзэнийг үзэгдэлд харав, **С ба Г 110:1–4**. Их Эзэн Иосефыг төлөөлөх ахлагч, орчуулагч, илчлэгч, үзмэрч, мөн бошиглогч хэмээн нэрлэв, **С ба Г 124:125**. Иосеф Смит энэ дэлхийд хүмүүний авралын төлөө зөвхөн Есүс Христийг эс тооцвол, бусад хэнээс ч илүү ихийг хийсэн юм, **С ба Г 135:3**

Бошиглогч Иосеф Смитээр авчрагдсан судрууд: 1830 онд Мормоны Ном гэдэг нэрээр нийтлэгдсэн орчуулга болох, тэнгэр элч Моронайгаар түүнд өгөгдсөн алтан ялтсуудын хэсгийг Иосеф орчуулжээ. Тэрээр мөн Их Эзэнээс Сүмийн үндсэн номлол ба зохион байгуулалтыг тодорхойлсон олон илчлэлтийг хүлээн авчээ. Эдгээр илчлэлтүүдээс олон нь эдүгээ Сургаал ба Гэрээнд орсон байна. Тэрчлэн тэрээр Мосе, Абрахам болон Матай нарын зарим бичээсүүдийн бурханлигаар нөлөөлөгдсөн орчуулгыг агуулсан Агуу Үнэт Сувд, хувийн түүх болон гэрчлэлийн түүвэр, мөн Сүмийн номлол хийгээд итгэлийг агуулсан арван гурван тунхгийг авчрах үүрэгтэй байв.

ИОСЕФ СМИТИЙН ОРЧУУЛГА

(ИСО). Бага Иосеф Смитийг

мөн үз

1830 оны зургадугаар сард бошиглогч Иосеф Смитийн эхэлсэн англи хэл дээрх Библийн Хаан Жеймсийн хувилбарын хянан тохиолдуулалт буюу орчуулга. Тэрээр орчуулга хийхийг Бурханаар зарлигдуулсан бөгөөд энэ нь бошиглогчийн дуудлагын нэг хэсэг хэмээн тооцогдож байв.

Иосеф 1833 оны долдугаар сар гэхэд орчуулгын ихэнхийг дуусгасан хэдий ч тэрээр гар бичмэлийг хэвлэхэд бэлтгэх үедээ хийсэн өөрчлөлт засваруудыг 1844 онд нас эцэслэх хүртлээ үргэлжлүүлсээр байв. Тэрээр амьд сэрүүн байхдаа орчуулгын зарим хэсгийг нийтлүүлсэн хэдий ч уг ажлыг нийтэд нь хэвлүүлэхийн тулд амьд сэрүүн байсан бол нэмэлт өөрчлөлтүүд оруулах байсан биз ээ. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Өөрчлөн зохион байгуулагдсан Сүм Иосеф Смитийн бурханлигаар нөлөөлөгдсөн орчуулгын анхны хэвлэлийг 1867 онд нийтлүүлжээ. Тэр үеэс хойш тэд хэд хэдэн удаагийн хэвлэлийг нийтлүүлсэн байна.

Орчуулгын явцад Бошиглогч олон зүйлийг мэдэж авчээ. Түүний орчуулгын ажлаас хамааран Сургаал ба Гэрээний нилээд хэдэн хэсэг хүлээн авагджээ (тухайлбал 76, 77, 91 ба 132). Түүнчлэн, Сургаал ба Гэрээнд тэмдэглэгдсэн, орчуулгын талаарх өвөрмөц заавруудыг Их Эзэн Иосефт өгчээ (С ба Г 37:1; 45:60–61; 76:15–18; 90:13; 91; 94:10; 104:58; 124:89). Эдүгээ Агуу Үнэт Сувдад орсон Мосегийн ном болон Иосеф Смит—Матай нь Иосеф Смитийн орчуулгаас шууд авагдсан ажээ.

Библиэс хаягдсан зарим тодорхой хийгээд эрхэм нандин зүйлүүдийг Иосеф Смитийн орчуулга сэргээсэн юм (1 Ниф. 13). Энэ нь Сүмийн албан ёсны Библи биш боловч, энэхүү орчуулга нь олон сонирхолтой санааг илэрхийлж байгаа бөгөөд Библийг ойлгоход нэн чухал ач холбогдолтой

юм. Энэ нь түүнчлэн Бошиглогч Иосеф Смитийн бурханлиг дуудлага хийгээд тохинууллын гэрч мөн.

ИОСЕФ, ТҮҮНИЙ САВАА.

Ефраим—Ефраимын буюу Иосефын саваа; Мормоны Номыг үз

ИОСЕФ Ф.СМИТ

Сүмийн зургаа дахь Ерөнхийлөгч; Хайрум Смит, Мари Фиелдинг Смит нарын ганц хүү. Тэрээр 1838 оны арваннэгдүгээр сарын 13-нд төрж, 1918 оны арваннэгдүгээр сарын 19-нд нас баржээ.

Иосеф Ф.Смит нас барагсдын гэтэлгэлийн талаарх үзэгдлийг хүлээн авчээ, **С ба Г 138**.

ИОСЕФЫН САВАА.

Ефраим—Ефраим буюу Иосефын савааг үз

ИОСИА

мэ 641–610 онд хаанчилж байсан Иудейн зөв шударга хаан (Хаад. дэд 22–24; Шаст. дэд 34–35). Түүний хаанчлалын үед Их Эзэний өргөөнд хуулийн ном бий болжээ (Хаад. дэд 22:8–13).

ИОХАН БАПТИСТ. Аароны

Санваар; Елиасыг *мөн үз*

Шинэ Гэрээн дэх Захариа, Элизабет хоёрын хүү. Мессиаг хүлээн авахад хүмүүсийг бэлтгэхийн тулд Иохан илгээгджээ (Иохан 1:19–27). Тэрээр Аароны санваарын түлхүүрүүдийг атгаж байсан бөгөөд Есүс Христэд баптисм хүртээжээ.

Исаиа болон бусад нь Иоханы үүргийн тухай бошиглож байлаа, **Иса.** 40:3 (Малах. 3:1; 1 Ниф. 10:7–10; 2 Ниф. 31:4). Шоронд хоригдож мөн цаазлагдав, **Мат.** 14:3–12 (Марк 6:17–29). Габриел Иоханы төрөлт хийгээд Захариад хийх тохинууллыг зарлан мэдэгдэв, **Лук** 1:5–25. Иохан Баптист бол агуу бошиглогч байсныг Есүс заадаг байлаа, **Лук**

7:24–28. Есүсийг Бурханы Хүү болохыг нь хүлээн зөвшөөрөв, **Иохан** 1:29–34. Иоханы шавь нар Есүсийн шавь нар болов, **Иохан** 1:25–29, 35–42 (Үйлс 1:21–22). Гайхамшгийг үйлдсэнгүй, **Иохан** 10:41. Амилуулагдсан хүн байж, Иосеф Смит, Оливер Каудери хоёрыг Аароны санваарт томилохоор илгээгдсэн байв, **С ба Г** 13 (С ба Г 27:7–8; ИС—Т 1:68–72). Түүнийг найман настай байхад тэнгэр элч түүнийг томилжээ, **С ба Г** 84:28.

ИОХАН, ЗЕБЕДИЙН ХҮҮ.

Зөөгдсөн хүмүүн биес; Иоханы илчлэлт; Мелкизедек санваар; Сайн Мэдээнүүд; Төлөөлөгчийг мөн үз

Шинэ Гэрээн дэх Арванхоёр Төлөөлөгчийн нэг, Зебедийн хүү, мөн Иаковын ах. Амьдралынхаа эхэн үед тэрээр загасчин байв (Марк 1:17–20). Тэр бол Иохан 1:40-д дурдагддаг, нэр нь гараагүй Иохан Баптистын шавь бололтой. Хожим нь тэрээр Есүс Христийн шавь байх дуудлага хүлээн авчээ (Мат. 4:21–22; Лук 5:1–11). Тэрээр Иоханы Сайн мэдээ, гурван захидал, мөн Илчлэлтийн номыг бичжээ. Тэр бол Иайрын охиныг босгоход (Марк 5:35–42), Хувиралтын Уулан дээр (Мат. 17:1–9), түүнчлэн Гетсеманид (Мат. 26:36–46) Их Эзэнтэй хамт байсан гурван хүний нэг юм. Тэрээр өөрийн бичээсүүдэд өөрийг нь Есүс (Иохан 13:23; 21:20) мөн түүнчлэн бусад шавь нар хайрладаг байсан хэмээн дурджээ (Иохан 20:2–8). Түүнчлэн Есүс түүнийг болон ах Бонергесыг нь аянгын хөвгүүд хэмээн нэрлэдэг байжээ (Марк 3:17). Цовдлолт хийгээд амилалтын таларх шастируудад түүнийг байнга иш татсан байдаг (Лук 22:8; Иохан 18:15; 19:26–27; 20:2–8; 21:1–2). Иохан хожим нь Патм уруу цөлөгдөж, тэнд Илчлэлтийн номыг бичжээ (Илч. 1:9).

Иохан хожмын үеийн илчлэлтэд байнга дурдагддаг (1 Ниф. 14:18–27; 3 Ниф. 28:6; Ифер 4:16; С ба Г 7; 27:12;

61:14; 77; 88:141). Эдгээр хэсгүүд Иоханы тухай библийн цэдгийг нотолж түүнчлэн Шинэ Гэрээний үед хийгээд эцсийн өдрүүдэд газар дэлхий дээр түүгээр хийлгэхээр Их Эзэнээс өгсөн тэрхүү ажлын ач холбогдол хийгээд түүний өөрийнх нь агуу байдлыг харах боломж олгодог билээ. Иохан нас бараагүй, харин Их Эзэний Хоёр дахь Ирэлтийн үеийг хүртэл дээр тохинуулах үйлчлэгчээр дэлхий дээр үлдэхээр зөвшөөрөгдсөнийг хожмын үеийн судрууд тодруулсан билээ (Иохан 21:20–23; 3 Ниф. 28:6–7; С ба Г 7).

Иоханы захидлууд: Эдгээр гурван захидлыг бичигч нэрээ хэлээгүй ч гэсэн, тэдгээрийг бүгдийг нь Төлөөлөгч Иохан бичсэн гэдгийг үг хэллэг нь яах аргагүй нотолдог.

1 Иохан 1 нь Бурхантай нөхөрлөхийг Гэгээнтнүүдэд сануулдаг. Бүлэг 2 нь Гэгээнтнүүд дуулгавартай байдлаар Бурханыг мэддэг гэдгийг онцлон тэмдэглэж, дэлхийг хайрлахгүй байхыг тэдэнд сургадаг. Бүлэг 3 нь бүхнийг Бурханы хүүхдүүд байж, бие биенээ хайрлахад уриалан дууддаг. Бүлэг 4 нь Бурхан бол хайр бөгөөд түүнийг хайрладаг тэдэн дээр оршдогийг тайлбарласан байдаг. Бүлэг 5 нь Христэд итгэх итгэлээр дамжин Гэгээнтнүүд Бурханаас төрдөг гэдгийг тайлбарладаг.

2 Иохан нь 1 Иохантай адил юм. Энд “сонгосон хатагтайн” хүүхдүүдийн итгэлтэй байдлын учир Иохан баяслыг эдэлдэг.

3 Иохан Гае хэмээх хүнийг түүний итгэлтэй байдал хийгээд үнэнийг хайрладаг хүмүүст тусалсных нь төлөө магтан сайшаасан байдаг.

Иоханы Сайн мэдээ: Шинэ Гэрээний энэ номонд Төлөөлөгч Иохан (1) Есүс бол Христ буюу Мессиа мөн, (2) Есүс бол Бурханы Хүү (Иохан 20:31) гэдгийг гэрчилжээ. Түүний дүрсэлсэн Есүсийн амьдралын зураглалууд нягт нямбайгаар сонгогдон дээрх зорилгыг харуулахад чиглэгдсэн байна. Мөнх бус оршихуйн

өмнөх үе дэх, Христийн байдал: тэрээр Бурхантай хамт байсан, тэрээр Бурхан, мөн тэрээр бүх зүйлийн бүтээгч байсныг өгүүлснээр уг ном эхэлдэг. Тэрбээр Эцэгийн Төрсөн Ганц Хүү болж маханбодид төрсөн билээ. Есүсийн бурханлиг чанар хийгээд нас барагсдаас амилсан түүний амилалтад онцгой анхаарч, түүний тохинууллын замналыг Иохан нарийн гаргажээ. Есүс бол гайхамшгуудаар, гэрчүүдээр, бошиглогчдоор, түүнчлэн Христийн өөрийнх нь дуу хоолойгоор нотлогдсон Бурханы Хүү мөн гэдгийг тэрээр тод томруунаар баталдаг. Иохан гэрэл ба харанхуй, үнэн ба худал, сайн ба муу, Бурхан ба чөтгөрийг харьцуулан заадаг. Есүсийн ариун байдал хийгээд Иудейн захирагчдын итгэлгүй байдлыг ийнхүү энгийн тодорхойгоор тунхагласан өөр цэдэг байхгүй биз ээ.

Иохан ихэвчлэн Иудей дэх Христийн тохинуулал, ялангуяа түүний мөнх бус тохинууллын сүүлчийн долоо хоногийн тухай бичсэн байхад Матай, Марк, Лук нар голчлон Галил дахь түүний тохинууллын тухай бичжээ. Энэхүү Сайн мэдээний нилээд зүйлүүд хожмын үеийн илчлэлтээр тодосгогдсон байна (С ба Г 7, мөн С ба Г 88:138–141).

Бүлгийн тоймыг “Сайн Мэдээнүүдээс” үз.

Илчлэлтийн ном: Иохан, Илчлэлтийг үз

ИОХАНЫ ИЛЧЛЭЛТ. Апокалипс;

Зебедийн хүү Иоханыг *мөн үз*

Төлөөлөгч Иоханд өгсөн илчлэлтээс бүрдсэн, Шинэ Гэрээний сүүлчийн ном. Дэлхийн, ялангуяа хожмын үеийн түүхийг үзэх нь түүнд соёрхогдов, (Илч. 1:1–2; 1 Ниф. 14:18–27; С ба Г 77). Иоханы илчлэлтийг бас Апокалипс ч гэдэг.

Иохан энэ илчлэлтийг Ефесээс холгүй Азийн эрэг талын Патм арал дээр (Илч. 1:9–10) Их Эзэний өдөр хүлээн авчээ. Илчлэлтийн яг тодорхой он мэдэгдээгүй болно.

Уг номыг ойлгох түлхүүрүүд нь 1 Ниф. 14:18–27 болон С ба Г 77-д байдаг (Ифер 4:15–16).

Бүлэг 1–3 нь номны оршил, мөн Ази дахь долоон сүмд бичсэн захидал юм. Зарим асуудлуудыг шийдвэрлэхэд нь Гэгээнтнүүдэд туслахын тулд Иохан уг захиdlуудыг бичжээ. Бүлэг 4–5 нь Иоханы хүлээн авсан үзэгдлүүд Бурханы болон Есүс Христийн сүр жавхлан хийгээд зөв шударга хүч чадлыг харуулсан байдаг. Бүлэг 6–9, 11-д Иохан лацдагдсан долоон номыг харсан бөгөөд лац бүр нь дэлхийн түүхийн мөчлөгийн нэг мянган жилийг төлөөлдгийг өгүүлжээ. Эдгээр бүлгүүд ихэвчлэн долоо дахь лацанд агуулагдсан үйл явдлуудын талаар өгүүлдэг (Илч. 8–9; 11:1–15-ыг үз). Бүлэг 10 нь Иоханы идсэн номны тухай дүрсэлдэг. Уг ном түүний гүйцэтгэж болох ирээдүйн ажил үүргийг төлөөлдөг. Бүлэг 12 нь тэнгэрт Сатан бослого гаргаж мөн зайлуулагдах үед эхэлсэн хилэнцийн тухай үзэгдлийг өгүүлдэг. Тэнд эхэлсэн тэрхүү дайн дэлхий дээр үргэжлэх учиртай ажээ. Бүлэг 13, 17–19-д Саганаар хянагддаг дэлхийн ёс бус хаант улсуудыг дүрсэлж мөн тэдний хувь тавилан, түүний дотор хилэнцийн устгалын тухай Иохан өгүүлсэн байдаг. Бүлэг 14–16 нь Есүс Христийн хоёр дахь ирэлтийн яг өмнөхөн хилэнцийн дундах Гэгээнтнүүдийн зөв шударга байдлыг дүрсэлдэг. Бүлэг 20–22 нь Мянган жил, Шинэ Иерусалимын үзэсгэлэнт хот, түүнчлэн дэлхийн түүхийн сүүлчийн үйл явдлуудыг дүрсэлдэг.

ИОШУА. Иерихог *мөн үз*

Хуучин Гэрээний бошиглогч бөгөөд удирдагч, Мосег залгамжлагч. Тэрээр Израилын хүүхдүүдийг гарахаас өмнө Египетэд төржээ (Тоол. 14:26–31). Калев тэр хоёр Канаанд илгээсэн арванхоёр тандуулын дунд байв. Тэд хамтран уг нутгийн талаар сайн илтгэл хийсэн байв (Тоол. 13:8, 17–14:10). Тэр 110 настайдаа наснаас хальжээ (Иош. 24:29). Иошуа бол

чин үнэнч, дайчин—бошиглогчийн үлгэр жишээ байлаа.

Иошуагийн ном: Иошуа энэ номыг зохиогч биш, харин гол баатар нь учраас уг номыг түүний нэрээр нэрлэжээ. Бүлэг 1–12 нь Канааныг байлдан дагуулсан тухай дүрсэлдэг; бүлэг 13–24 нь газар нутгаа хуваасан Израилын овгуудын тухай түүнчлэн Иошуагийн сүүлчийн зөвлөгөөнүүдийн талаар өгүүлдэг.

Иошуагийн номон дахь хоёр онцгой шүлэг бол судруудын талаар бясалгахыг Их Эзэн түүнд зарлигласан зарлиг (Иош. 1:8) болон Их Эзэнд итгэлтэй байхад хүмүүсийг уриалан дуудах Иошуагийн дуудлага юм (Иошуа 24:15).

ИРЭХ. Дуулгавартай,

Дуулгавартай байдал,

Дуулгавартай дагах; Шавийг мөн үз

Судруудад, хэн нэгнийг дагаснаар буюу дуулгавартай дагаснаар ойр байхыг “Христэд ирэгтүн, мөн түүгээр төгөлдөржигтүн” (Моро. 10:32) гэсэн өгүүлбэрээр хэлдэг.

Чихээ нээ, мөн над уруу ир, **Иса.** 55:3. Эцэж туйлдсан хүмүүс ээ, над уруу ир, **Мат.** 11:28. Бяцхан хүүхдүүдийг над уруу ирэхийг бүү болиул, **Мат.** 19:14. Хэрэв хэн нэгэн Миний араас явахыг хүсвэл, тэр хүн өөрийгөө үгүйсгэг, **Лук** 9:23. Над уруу ирдэг хүн өлсөхгүй, **Иохан** 6:35. Христ бүхнийг өөртөө ирэхийг урьдаг, **2 Ниф.** 26:33. Надад ир, мөн аврагд, **3 Ниф.** 12:20. Христэд ир, **Моро.** 10:32. Бүхнийг Христэд ирэхэд урь, **С ба Г** 20:59. Надад ир, мөн чиний бие амьдрах болно, **С ба Г** 45:46.

ИСААК. Абрахамыг мөн үз

Хуучин Гэрээний патриарх. Абрахам Сара хоёрт өтлөх насанд нь тэрээр төрсөн нь гайхамшиг байлаа (Эхл. 15:4–6; 17:15–21; 21:1–8). Исаакаар тахил өргөхөд Абрахам бэлэн байсан нь Бурхан болон түүний Төрсөн Ганц Хүүтэй төстэй юм (Иаков 4:5). Исаак бол Абрахамын гэрээний амлал-

туудын өв залгамжлагч байв (Эхл. 21:9–12; 1 Ниф. 17:40; С ба Г 27:10).

Исаак төрөв, **Эхл.** 21:1–7. Мориа уулан дээр тахилд өргөгдөх гэж байв, **Эхл.** 22:1–19 (С ба Г 101:4). Гэрлэв, **Эхл.** 24. Хөвгүүдээ төвхнүүлэв, **Эхл.** 27:1–28:9. Абрахам болон Иаковын хамт өргөмжлөлийг хүлээн авав, **С ба Г** 132:37 (Мат. 8:11).

ИСАИА

мээ 740–701 онд бошиглож асан Хуучин Гэрээний бошиглогч. Хаан Хезекиагийн ерөнхий зөвлөх байсан болохоор Исаиа шашин, улс төрийн агуу нөлөөтэй байжээ.

Есүс Исаиаг бусад аль ч бошиглогчоос илүү олонтаа дурдсан байдаг. Түүнчлэн Шинэ Гэрээнд Исаиаг Петр, Иохан, түүнчлэн Паул нар олонтаа иш татсан байдаг. Мормоны Ном болон Сургаал ба Гэрээнд бусад аль ч бошиглогчийнхоос илүү олон ишлэл Исаиагаас орсон байдаг бөгөөд Исаиаг тайлбарлахад нэн их тустай юм. Нифай өөрийн хүмүүст Исаиагийн бичээсүүдээс заадаг байв (2 Ниф. 12–24; Иса. 2–14). “Исаиагийн үгс агуу хийгээд” Исаиагийн бошиглосон бүх зүйл биелэгдэх болно гэдгийг Их Эзэн нифайчуудад ярьжээ (3 Ниф. 23:1–3).

Исаиагийн ном: Хуучин Гэрээн дэх нэг ном. Исаиагийн бошиглолдуудаас олон нь дэлхийн тохинуулалд (Иса. 9:6) хийгээд эцсийн өдөр Агуу их Хаан (Иса. 63) болж ирэх Гэтэлгэгчийн ирэлтийн тухай өгүүлсэн байдаг. Түүнчлэн тэрээр Израилын ирээдүйн тухай ихийг бошигложээ.

Бүлэг 1 нь номны үлдсэн хэсгийн эхлэл хэсэг юм. Исаиа 7:14; 9:6–7; 11:1–5; 53:1–12; түүнчлэн 61:1–3 нь Аврагчийн үүрэг зорилгыг угтан хэлсэн байдаг. Бүлэг 2, 11, 12 түүнчлэн 35 нь сайн мэдээ сэргээгдэх, Израил цуглуулагдах, мөн ангасан нутаг сарнай лугаа адил цэцэглэн хөгжих хожмын өдрүүд дэх үйл явдлуудын тухай өгүүлдэг. Бүлэг 29 нь Мормоны Ном ирэх тухай

бошиглолыг агуулдаг (2 Ниф. 27). Бүлэг 40–46 нь үнэн Бурхан Иехова үнэн Бурханыг мэддэггүй бишрэн шүтэгчдийн хиймэл бурхдаас үлэмж давууг тунхагласан байдаг. Үлдсэн бүлгүүд 47–66 нь Израилын сүүлчийн сэргэлт хийгээд Их Эзэн өөрийн хүмүүсийн дунд оршин суух Сионы үндэслэн байгуулалтын тухай өгүүлдэг.

ИССАХАР. Израил; Исаакийн хүү
Иаковыг мөн үз

Хуучин Гэрээн дэх Иаков Леа хоёрын хүү (Эхл. 30:17–18; 35:23; 46:13). Түүний үр удмынхан Израилын арванхоёр овгийн нэг болжээ.

Иссахарын овог: Иссахарыг адисалсан Иаковын адислал Эхлэл 49:14–15-д байдаг. Канаанд суурьшсаны дараа уг овог Есдраелоны талыг оролцуулан Палестины хамгийн үржил шимтэй хэсэг газрыг хүлээн авчээ. Иссахарын хилийн дотор Иудейн түүхэнд чухал ач холбогдол бүхий нилээд газрууд жишээлбэл, Кармел, Мегиддо, Дотан, Гилбоа, Иезреел, Табор, түүнчлэн Назар байдаг (Иош. 19:17–23).

ИТГЭЛ, ИТГЭХ. Есүс Христ;
Найдварыг мөн үз

Хүнд буюу ямар нэг зүйлд, ялангуяа Бурхан болон Есүс Христэд итгэлтэй байх, ямар нэг зүйлийг үнэн гэдгийг хүлээн зөвшөөрөх. Бурханы хаант улсад аврагдахын тулд хүн наманчилж мөн Есүс Христэд итгэх ёстой (С ба Г 20:29). Сүнсний зүйлүүдэд итгэх нь Бурхан болон түүний Сүнсэнд итгэж найдахыг багтаадаг. Судруудад нэн олонтаа хэрэглэгдсэнээр, итгэл найдвар бол Есүс Христэд итгэх итгэл бөгөөд энэ нь түүнийг дуулгавартай дагахад хүнийг удирдаг байна. Итгэл нь хүнийг аврал уруу удирдахын тулд Есүс Христэд төвлөрөх ёстой. Хожмын үеийн Гэгээнтнүүд Бурхан Эцэг, Ариун Сүнс, санваарын хүч болон сэргээгдсэн сайн мэдээний бусад чухал зүйлүүдэд мөн итгэдэг.

Итгэл нь, харагдахгүй хэдий ч, үнэн зүйлүүдэд итгэх найдварыг өөртөө багтаадаг (Евр. 11:1; Алма 32:21; Ифер 12:6). Итгэл нь Бурханаар илгээгдсэн эрх мэдэл бүхий гүйцэтгэгчдээр заагддаг сайн мэдээг сонссоноор оргилон хөгждөг (Ром 10:14–17). Гайхамшгууд нь итгэлийг төрүүлэхгүй ч гэсэн, хүчтэй итгэл нь Есүс Христийн сайн мэдээнд дуулгавартай байх явдлаар хөгждөг. Өөрөөр хэлбэл, итгэл зөв шударга байдлаас ирдэг (Алма 32:40–43; Ифер 12:4, 6, 12; С ба Г 63:9–12).

Үнэн итгэл нь гайхамшгууд, үзэгдлүүд, зүүд, эдгээлт, түүнчлэн Бурханаас өөрийн Гэгээнтнүүдэд өгдөг бүх бэлгүүдийг авчирдаг. Итгэлээр хүн нүглүүдийн ангижралыг олж, улмаар Бурханы дэргэд амьдрах боломжтой болдог. Итгэл дутагдах нь хүнийг алдсын улмаас ирдэг цөхрөл уруу хөтөлдөг (Моро. 10:22).

Өөрийн Бурхан Их Эзэнд итгэ; түүний бошиглогчдод итгэ, **Шаст.** дэд 20:20. Тэр намайг алах ч гэсэн би түүнд л найдах болно, **Иов** 13:15. Хүнд итгэхээс Их Эзэний дотор хоргодох нь дээр, **Дуул.** 118:8. Бүх зүрх сэтгэлээрээ Эзэнд итгэ, **Сур.** үгс 3:5. Их Эзэн чамд эр зориг болно, **Сур.** үгс 3:26. Бурхан өөрт нь итгэсэн зарц нараа аварсан, **Дан.** 3:19–28. Бурханд тэрээр итгэж байсан учраас Даниел арслангийн торонд гэмтээгүй, **Дан.** 6:23. Зөв шударга хүн итгэлээрээ амьдарна, **Хаб.** 2:4. Чи итгэсэнчлэн тэр чинь чамд үйлдэгдэх болно, **Мат.** 8:13. Итгэл чинь чамайг эдгээлээ, **Мат.** 9:22 (Марк 5:34; Лук 7:50). Итгэлийн чинь дагуу болог, **Мат.** 9:29. Хэрэв гичийн үр төдийхөн итгэл та нарт байвал, юу ч та нарт боломжгүй биш байх болно, **Мат.** 17:20 (Лук 17:6). Та нар итгэлтэйгээр залбиран гуйсан бүх зүйлсээ хүлээн авах болно, **Мат.** 21:22. Бүү ай, зөвхөн итгэ, **Марк** 5:36. Итгэлтэй хүнд бүх юм боломжтой, **Марк** 9:23–24. Хэн итгэж баптисм хүртэнэ, тэр аврагдах болно, **Марк** 16:16 (2 Ниф. 2:9; 3 Ниф. 11:33–35).

Итгэл чинь сульдахгүйн тулд би чиний төлөө залбирлаа, **Лук** 22:32. Хүүд итгэгч хэн ч мөнх амьтай болно, **Иохан** 3:16, 18, 36 (Иохан 5:24; С ба Г 10:50). Та бол Христ гэдэгт бид итгэцгээсэн, **Иохан** 6:69. Надад итгэдэг хүн үхэвч, амьдарна, **Иохан** 11:25–26. Христийн нэрэнд итгэх итгэл нь энэ хүнийг хүчтэй болгожээ, **Үйлс** 3:16. Итгэл нь Бурханы үгийг сонссоноор ирдэг, **Ром** 10:17. Хэрэв Христ амилагдаагүй бол, та нарын итгэл хоосон юм, **1 Кор.** 15:14. Итгэл хайраар дамжин ажилладаг, **Гал**, 5:6. Нигүүлслээр та нар итгэлээр аврагдсан юм, **Ефес** 2:8 (2 Ниф. 25:23). Итгэлийн бамбайг авагтун, **Ефес** 6:16 (С ба Г 27:17). Би замаа дуусгаж, итгэлээ сахьсан, **2 Тим.** 4:7. Итгэгч бид түүний амралт уруу ордог, **Евр.** 4:3. Итгэл бол бидний найддаг зүйлсийн бодит байдал мөн, **Евр.** 11:1. Итгэлгүйгээр түүний таалалд нийцнэ гэдэг боломжгүй юм, **Евр.** 11:6. Итгэл хэрэв эс ажилллах аваас, үхмэл юм, **Иаков** 2:17–18, 22. Христийг үзэгдэх үед бид түүний өмнө зоригтой байна, **1 Иохан** 2:28. Есүс Христэд итгэ, мөн бие биенээ хайрла, **1 Иохан** 3:23. Би явж, Их Эзэний зарлигласан зүйлүүдийг хийх болно, **1 Ниф.** 3:7. Хэрэв тэд түүнд итгэх итгэлээ бодитой болговол Их Эзэн хүмүүний үрсийн тул бүхнийг хийх боломжтой билээ, **1 Ниф.** 7:12. Бөмбөрцгийн зүйлүүд нь итгэлийн дагуу ажилладаг байв, **1 Ниф.** 16:28. Би танд үүрд итгэх болно, **2 Ниф.** 4:34. Мессиа түүнд итгэдэг нэгээхнийг ч устгахгүй, **2 Ниф.** 6:14. Израилын Ариун Нэгэнд төгс итгэлтэй байж, наманчлан, мөн мөн түүний нэрээр баптисм хүртэгтүн, **2 Ниф.** 9:23. Иудей хүмүүс Христэд итгэхийг ятгуулах тэр үеийг хүртэл цээрлүүлэгдэх болно, **2 Ниф.** 25:16. Христ хүмүүний үрсийн дунд тэдний итгэлийн дагуу хүчит гайхамшгуудыг үйлддэг, **2 Ниф.** 26:13 (Ифер 12:12; Моро. 7:27–29; 34–38). Есон бус нифайчууд хүүхдүүдийнхээ итгэлийг алдав, **Иаков** 2:35. Христэд итгэх түү-

ний итгэлийн учир Иносын нүглүүд өршөөгджээ, **Инос** 1:3–8. Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр дамжихаас бусдаар хэн дээр ч аврал ирэх нь үгүй, **Моз.** 3:12. Хэрэв та нар эдгээр бүх зүйлд итгэвэл, тэдгээрийг өөрсдөө үйлдэхэд анхаарагтун, **Моз.** 4:10. Түүний нэрэнд итгэх итгэлээр дамжин зүрх сэтгэл өөрчлөгддөг, **Моз.** 5:7. Баярлан цэнгэ, Бурханд итгэ, **Моз.** 7:19. Бурханд найдлага тавьсан хэн боловч хожмын өдөр өргөгдөх болно, **Моз.** 23:22. Бурханы үйлчлэгчдийн залбирлууд тэдний итгэлийн дагуу хариулагддаг, **Моз.** 27:14. Хүү өөрийнх нь нэрэнд итгэх тэдгээрийн гэмийг өөр дээрээ авах болно, **Алма** 11:40. Христэд итгэх бидний итгэлийн дагуу хүч чадлыг бидэнд өгнө үү, **Алма** 14:26. Итгэлд Бурхан нэрийг дуудагтун, **Алма** 22:16. Бурханы үгэнд албадуулалгүйгээр итгэх тэд ивээгдсэн, **Алма** 32:16. Итгэл нь юмсын тухай төгс мэдлэгтэй байх явдал биш юм, **Алма** 32:21 (Ифер 12:6). Хэрэв итгэх хүслээс илүү нь байхгүй аваас, энэ хүслээ өөрсөддөө ажиллуулцгаая, **Алма** 32:27. Мөн энэ нь өсч эхлэхэд та нар үүнийг итгэлээр тэжээгтүн, **Алма** 33:23 (Алма 32:28). Бурханд найдлага тавьсан хэн боловч зүдгүүрүүддээ дэмжигдэх болно, **Алма** 36:3, 27. Тэдний хамгаалагдан үлдсэн нь тэд үлэмж итгэлтэй байсны улмаас Бурханы гайхамшигт хүчнийх байлаа, **Алма** 57:25–27. Бурханы Хүүг итгэлтэйгээр харсан болгон амьдарч болох билээ, **Хил.** 8:15. Хэрэв та нар Христийн нэрэнд итгэх аваас, та нар наманчлах болно, **Хил.** 14:13. Христэд итгэх хэн боловч Эцэгт мөн итгэх болой, **3 Ниф.** 11:35. Итгэл чинь би та нарыг эдгээхэд хангалттай гэдгийг харж байна, **3 Ниф.** 17:8. Хүмүүн хэзээ ч Их Эзэнд Жаредын ах шиг итгэж байгаагүй, **Ифер** 3:15. Итгэл бол найдагдсан хэдий ч үзэгддэггүй зүйлүүд юм, **Ифер** 12:6. Гайхамшгуудыг үйлддэг тэд бүгд тэдгээрийг итгэлээр үйлддэг, **Ифер** 12:12–18. Хэрэв тэд надад итгэх итгэлтэй байх аваас, би сул зүйлүүдийг

тэдэнд хүчтэй болгох болгоно, **Ифер** 12:27–28, 37. Итгэл, найдвар хийгээд энэрлийн тухай Мормон заадаг байв, **Моро**. 7. Христэд итгэхийг ятгах зүйл бүхэн Христийн хүчээр илгээгдсэн байдаг, **Моро**. 7:16–17. Та нар хүлээж авах болно гэсэн итгэлтэйгээр, сайн болох ямар ч зүйлийг миний нэрээр Эцэгээс гуйхад, болгоогтун, энэ нь та нарт хийгдэх болно, **Моро**. 7:26. Христэд итгэх итгэлтэй тэд сайн зүйл болгонтой нэгдэн нийлэх болно, **Моро**. 7:28. Хэрэв та нар Христэд итгэлтэй байж, асуух аваас, тэрээр үнэнийг та нарт мэдүүлэх болно, **Моро**. 10:4. Хүний гарт бүү найд, **С ба Г** 1:19. Христийн үгст итгэх хэнд ч болов Сүнсний илэрхийлэл өгөгдөх болно, **С ба Г** 5:16. Та нар итгэлгүйгээр юуг ч хийж чадахгүй; тиймийн тул итгэлд асуугтун, **С ба Г** 8:10. Энэ нь тэдний залбирлуудад тэдний итгэлийн дагуу тэдэнд соёрхогдох ёстой, **С ба Г** 10:47; 52. Сайныг үйлдэхэд хөтөлдөг Сүнсэнд найдлага тавь, **С ба Г** 11:12. Их Эзэний нэрэнд итгэх хэн боловч Бурханы хөвгүүд болно, **С ба Г** 11:30 (Иохан 1:12). Бүх хүмүүн түүний нэрэнд итгэх итгэлд, эцсээ хүртэл тэвчих ёстой, **С ба Г** 20:25, 29. Христийн ач ивээлээр дамжсан зөвтгөл нь шударга хийгээд үнэн юм, **С ба Г** 20:30. Сүнс итгэлийн залбирлаар та нарт өгөгдөх болно, **С ба Г** 42:14. Заримд нь бусдын үгэнд итгэх нь өгөгддөг, **С ба Г** 46:14. Итгэгч хүнийг тэмдэг дагадаг, **С ба Г** 58:64 (С ба Г 63:7–12). Итгэл нь тэмдгүүдээр ирдэггүй, харин тэмдгүүд итгэдэг тэднийг дагалддаг, **С ба Г** 63:9–12. Христэд итгэх итгэлийг эцэг эхчүүд хүүхдүүддээ заах ёстой, **С ба Г** 68:25. Тэрээр надад итгэгч мөн тэрээр будлиулагдахгүй байх болно, **С ба Г** 84:116. Бүр сурлагаар, мөн тэрчлэн итгэлээр сурахыг эрэлхийлэгтүн, **С ба Г** 88:118. Тэгээд итгэлтэй байдал чинь Бурханы оршихуйд хүчтэй байх болно, **С ба Г** 121:45. Итгэж, наманчилж мөн багтисм хүртсэн хүмүүс Ариун Сүнсийг хүртсэн авах

болно, **Моце** 6:52. Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл бол сайн мэдээний анхдагч зарчим мөн, **ИТ**. 1:4.

ИТГЭЛГҮЙ БАЙДАЛ. Итгэл,

Итгэхийг мөн үз

Бурхан хийгээд түүний сайн мэдээнд итгэх итгэл дутуу байх.

Тэдний итгэлгүй байдлаас болж тэр тэнд олон гайхамшиг үйлдсэнгүй, **Мат**. 13:58. Итгэлгүйн улмаас Есүсийн шавь нар чөтгөрийг гаргаж чадсангүй, **Мат**. 17:14–21. Итгэлгүй байгаад минь та туслаач, **Марк** 9:23–24. Есүс Төлөөлөгчдийнхөө итгэлгүй хийгээд хатуу зүрхтэйг эмслэв, **Марк** 16:14. Итгэлгүй байдал нь Бурханы итгэмжит байдлыг хүчингүй болгоно гэж үү? **Ром** 3:3. Нэгэн үндэстэн бууран доройтож мөн итгэлгүйдээ мөхсөнөөс нэг хүн эрсэдсэн нь дээр, **1 Ниф**. 4:13. Тэд итгэлгүйдээ бууран доройтох цаг нь ирэхэд тэрээр тараагдсан бас бут цохигдсон болгоно, **2 Ниф**. 1:10–11 (С ба Г 3:18). Тэд итгэлгүйнхээ улмаас Бурханы үгийг ойлгож чадах нь үгүй, **Моз**. 26:1–5. Тэд итгэлгүй учраас би иудейчүүдэд агуу гайхамшгуудыг үзүүлж чадах нь үгүй, **3 Ниф**. 19:35. Итгэлгүйн улмаас та нарын оюун өнгөрсөн үеүдэд харанхуйлагдсан байна, **С ба Г** 84:54–58.

ИТГЭЛИЙН ТУНХАГ. Агуу

Үнэт Сувд; Бага Иосеф

Смитийг мөн үз

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийн итгэлийн үндсэн арвангурван тунхаг.

Сүмийн гишүүд юунд итгэдгийг мэдэхийг хүссэн *Чикаго Демократ* сонин эрхлэгч Жон Вентвортод Иосеф Смит анх үүнийг бичжээ. 1842 оны гуравдугаар сард Вентвортын Захиа нэртэйгээр анх удаа *Times and Seasons* сэтгүүлд хэвлэгджээ. 1880 оны аравдугаар сарын 10-нд Итгэлийн Тунхаг нь Сүмийн гишүүдээр албан ёсоор судар болон

зөвшөөрөгдөж Агуу Үнэт Сувдын хэсэг болсон байна.

ИУДА

Шинэ Гэрээнд, Есүсийн дүү нарын нэг бөгөөд Иудагийн захидлыг зохиогч бололтой (Мат. 13:55; Иуда 1:1).

Иудагийн захидал: Энэ ном итгэлээрээ суларч байсан зарим Гэгээнтнүүдэд Иудагаас бичсэн захидлаас бүрддэг. Христэд итгэгчид хэмээн нэрлэгддэг боловч хэрэг дээрээ ёс суртахуунгүй, үнэн Бурханыг үл мэдэгч шашныг шүтэн биширч, ёс суртахууны хуулиудад дуулгавартай байхаас чөлөөлөгддөг хэмээн мэдэгддэг хүмүүс тэднийг сулруулдаг байлаа. Сүнсний хувьд аюултай энэ зүйлийг Гэгээнтнүүдэд мэдрүүлж, итгэлтэй хэвээр үлдэхэд нь тэднийг урамшуулан дэмжихийг Иуда хүсч байв.

Иудагийн зарим онцлог хэсгүүд гэвэл тэнгэр дэх дайн болон Люцифер хийгээд түүний элчүүд мөнх бус байдлын өмнөх үеэсээ доош хаягдсан тухай өгүүлдэг шүлэг 6 (Абр. 3:26–28), түүнчлэн Енохын бошиглолыг иш татсан шүлэг 14–15 юм.

ИУДА. Библи; Израил;
Иудейчүүдийг мөн үз

Хуучин Гэрээнд, Иаков Леа хоёрын дөрөв дэх хүү (Эхл. 29:35; 37:26–27; 43:3, 8; 44:16; 49:8). Иудаг Иаковын хөвгүүдийн дунд зүй ёсны удирдагч байхаар мөн Шилог (Есүс Христ) түүний үр удам байхаар Иаков адисалжээ (Эхл. 49:10).

Иудагийн овог: Иудагийн овог Канаанд суурьшсанахаа дараа удирдлагыг авчээ. Үүний гол өрсөлдөгч нь Ефраимын овог байв. Мосе Иудагийн овгийг адисалжээ (Дэд хууль 33:7). Соломоны хаанчлалын дараа Иудейн овог Иудагийн хаант улс болов.

Иудейн хаант улс: Рехобоамын хаанчлалд Соломоны эзэмшлүүд ихэвчлэн Ефраимын болон Иудагийн овгуудын хоорондох атаа жөтөөний

улмаас тусгаар хоёр хаант улсад хуваагджээ. Өмнөд хаант улс буюу Иудейн хаант улс нь Иудагийн овог болон Бениамины үлэмж хэсгийг багтааж байв. Иерусалим нийслэл нь байлаа. Нийтэд нь авч үзвэл уг хаант улс Умард Хаант Улсыг бодвол Иеховаг шүтэн бишрэхэд илүү итгэлтэй хэвээр байлаа. Умардаас болон дорнодоос хийж байсан довтолгоонд Иудей бага өртөж, дээд эрх мэдэл нь Вавилоны боолчлол хүртэл Давидын гэр бүлийнхний гарт байв. Илүү их алдартай, илүү их хүчирхэг Израилын хаант улс унасны дараа Иудейн хаант улс 135 жил оршин тогтносон юм.

Иудагийн саваа: Энэ нь Библид Иудагийн угсааны цэдэг болон гардаг (Езек. 37:15–19). Израилын угсааны олон салаа мөчрүүд цугларах хожмын өдрүүдэд, тэдний ариун нандин цэдгүүд тэрчлэн бас цуглуулагдах болно. Судрын эдгээр цэдгүүд бие биенээ нөхөж, Есүс бол Христ, Израилын Бурхан, мөн бүх дэлхийн Бурхан болох тухай нэгдмэл гэрчлэлийг бий болгодог (2 Ниф. 3; 29; ИСО, Эхл. 50:24–36).

ИУДАГИЙН САВАА. Иуда—
Иудагийн савааг үз

ИУДАС, ИАКОВЫН АХ

Шинэ Гэрээнд, Есүс Христийн анхны арванхоёр Төлөөлөгчийн нэг (Лук 6:13–16). Тэрээр түүнчлэн Леббае Таддай гэгддэг байсан бололтой (Мат. 10:2–4).

ИУДАС, ИСКАРИОТЫН

Шинэ Гэрээн дэх Есүс Христийн Арванхоёр Төлөөлөгчийн нэг (Мат. 10:4; Марк 14:10; Иохан 6:71; 12:4). Түүний овог “Кериотын хүн” гэсэн утгатай. Тэрээр Иудагийн овгийн хүн байсан бөгөөд Галилынх бус цорын ганцхан Төлөөлөгч байв. Иудас Их Эзэнээс урвасан билээ.

Тэргүүн тахилч нарын нэгэнд Христийг барьж өгсний төлөө гучин

мөнгөн зоос авав, **Мат.** 26:14–16 (Зех. 11:12–13). ЭЗЭНийг үнсэж, түүнээс урвав, **Мат.** 26:47–50 (Марк 14:43–45; Лук 22:47–48; Иохан 18:2–5). Өөрийгөө дүүжлэв, **Мат.** 27:5. Сатан Иудасын дотор оров, **Лук** 22:3 (Иохан 13:2; 26–30). Есүсээс Иудас урвах тухай Давид өгүүлэв, **Үйлс** 1:16 (Дуул. 41:9).

ИУДЕЙЧҮҮД. Израил; Иудаг
мөн үз

Иудейчүүд гэдэг нь (1) Иаковын арванхоёр хүүгийн нэг Иудагийн үр удмынхан, (2) эртний өмнөд Иудагийн хаант улсын хүмүүс, (3) эсвэл угсаа гарлаараа иудей буюу иудей биш байж болох хэдий ч иудейн шашин, амьдралын хэв маяг, уламжлалыг баримталдаг хүмүүс юм. Иаковын бүх удам угсааныхныг *Иудей* хэмээн нэрлэж хэвшсэн боловч энэ нь буруу юм. Энэ нь Иудагийн хаант улсын хүмүүсээр, эсвээс нэн ялангуяа өнөө үед Иудагийн овог болон түүнтэй холбоотой хүмүүсээр хязгаарлагддаг.

Шилог иртэл хааны таяг Иудагаас салахгүй, **Эхл.** 49:10. Христийн сайн мэдэг бол түрүүнд нь иудейчүүдэд өгөгдөх авралын төлөөх Бурханы хүч билээ, **Ром** 1:16. Их Эзэн иудейчуудийн дунд нэгэн Бошиглогчийг—бүр Мессиаг төрүүлэн гаргах болно, **1 Ниф.** 10:4. Тэрхүү ном Иудейн амнаас үүссэн тэр цагт, уг зүйлүүд тодорхой бөгөөд нандин байлаа, **1 Ниф.** 14:23. Иудейчүүд бүх үндэстнүүдийн дунд тараагдах болно, **2 Ниф.** 25:15. Иудейчүүд бол миний эртний гэрээт хүмүүс, **2 Ниф.** 29:4. Тараагдсан иудейчүүд Христэд итгэж эхлэх болно, **2 Ниф.** 30:7. Иудейчүүд өөрсдөө дээр нь барьж болох чулууг эсэргүүцэх болно, **Иаков** 4:14–16. Есүс бол чухамхүү тэр Христ байсныг гэрчлэх өөр гэрч иудейчүүдэд байх болно, **Морм.** 3:20–21. Хожмын өдрүүдэд Иудей үндэстэнд хоёр бошиглогч төрөн гарах болно, **С ба Г** 77:15. Бүх үндэстнүүдийг, эхлээд Харийнханыг, дараа нь иудейчүүдийг дуудаг-

тун, **С ба Г** 133:8. Тэдгээр өдрүүдэд иудейчүүдэд агуу гай зовлон тохиох болно, **ИС—Мат.** 1:18.

ИФЕР. Жаредчуудыг *мөн үз*

Мормоны Номон дахь жаредчуудын сүүлчийн бошиглогч (Ифер 12:1–2).

Иферийн ном: Жаредчуудын цэдгийн нэг хэсгийг агуулсан, Мормоны Номны нэг ном. Жаредчууд бол Лихайн хүмүүсээс олон зууны өмнө дэлхийн баруун хагаст амьдарч байсан бүлэг хүмүүс байв. Иферийн номыг Лихайн хүмүүсийн олсон хорин дөрвөн ялтсаас авчээ. (Моз. 8:8–9).

Бүлэг 1–2 нь Бабелын Цамхагийн үед жаредчууд хэрхэн гэр орноо орхин, эдүгээ Америк тив хэмээн нэрлэгддэг газар уруу аяллаа эхэлсэн тухай өгүүлдэг. Бүлэг 3–6 нь жаредын ах мөнх бус байдлын өмнөх Аврагчийг харсныг хийгээд жаредчууд ачааны хөлөг онгоцоор аялсныг тайлбарладаг. Бүлэг 7–11 нь жаредчуудын түүхийн ихэнх үед ноёрхож байсан ёс бус явдлын түүхийг цаашид үргэлжлүүлж хүүрнэдэг. Иферийн цэдгийг хянан тохиолдуулсан Моронай бүлэг 12–13-т итгэлээр хийгддэг гайхалтай зүйлүүдийн тухай, Христийн тухай хийгээд ирэх Шинэ Иерусалимын тухай бичжээ. Бүлэг 14–15 нь жаредчууд хүчирхэг үндэстэн болсон хэдий ч, ёс бусын улмаас иргэний дайнаар хэрхэн устгагдсан тухай өгүүлдэг.

ИХ ЭЗЭН. Бурхан, Бурхан

Тэргүүтэн; Есүс Христийг *мөн үз*

Бурхан Эцэг болон Аврагч Есүс Христийн гүн хүндэтгэл, бишрэлийг илэрхийлсэн нэр. Уг нэр нь өөрсдийн бүх бүтээлүүдийн энэрэл хайрын дээд эзэд болох тэдний байр суурийг илэрхийлдэг.

ЭЗЭНд хэтэрхий хэцүү юм гэж байдаггүй, **Эхл.** 18:14. ЭЗЭН Мосетой нүүр тулан ярилцав, **Ег.** 33:11. Чи өөрийн ЭЗЭН Бурханаа хайрлах ёстой, **Дэд зууль** 6:5 (Мат. 22:37; Марк 12:30). Миний өөрийн болон миний удам

угсааны хувьд гэвэл бид ЭЗЭНД үйлчлэх болно, **Иош.** 24:15. ЭЗЭН бол миний хоньчин, **Дуул.** 23:1. ЭЗЭН тулалдаанд хүчирхэг мөн чадалтай хүчтэй билээ, **Дуул.** 24:8. ЭЗЭН Иехова бол миний хүчин чадал мөн, **Иса.** 12:2 (2 Ниф. 22:2). ЭЗЭН бибээр чиний Аврагч мөн чиний Гэтэлгэгч мөн, **Иса.** 60:16. Чи Эзэн Бурханаа шүтэн бишрэх ёстой, **Мат.** 4:10 (Лук 4:8). ЭЗЭНий хийсэн зүйлүүд хичнээн агуу билээ, **Марк** 5:19. Нэг л ЭЗЭН Есүс Христ байдаг, **1 Кор.** 8:6. Нэг ЭЗЭН, нэг итгэл, нэг баптисм байдаг, **Еф.** 4:5. ЭЗЭН өөрөө тэнгэрээс бууж ирэх болно, **1 Тесл.** 4:16. Би явж мөн Их Эзэний зарлигласан зүйлийг хийх болно, **1 Ниф.** 3:7. Их Эзэн ядуусыг зөв шударгаар шүүх болно, **2 Ниф.** 30:9. Их Эзэн Бурхан, Абрахамын Бурхан, израилчуудыг боолчлолоос чөлөөлсөн билээ, **Алма** 29:11. Наманчлал ба Их Эзэнд итгэх итгэлээс өөр юу ч хүмүүсийг аварч чадахгүй, **Хил.** 13:6 (Моз. 3:12). Өөрийн Их Эзэн Есүс Христийн үгсийг сонсогтун, **С ба Г** 15:1. Их Эзэний нүүрийг ямагт эрэлхийлэгтүн, **С ба Г** 101:38. Их Эзэн Хоёр дахь Ирэлтээрээ гаднах төрхөөрөө улаан байх болно, **С ба Г** 133:48 (Иса. 63:1–4). Абрахам Их Эзэнтэй нүүр тулан ярилцав, **Абр.** 3:11. Сайн мэдээний анхдагч зарчим бол Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл мөн гэдэгт бид итгэдэг, **ИТ** 1:4.

ИХ ЭЗЭНИЙ ЗАЛБИРАЛ.

Залбирлыг *мөн үз*

Өөрийн шавь нарын төлөө бүх залбирлын загвар болгон Аврагчаас өгсөн залбирал (**Мат.** 6:9–13; 3 Ниф. 13:9–13).

ИХ ЭЗЭНИЙ ӨДӨР.

Есүс Христийн Хоёр дахь Ирэлт; Хүндэтгэлийн өдөр; Эцсийн шүүлтийг үз

ИХ ЭЗЭНИЙ ӨРГӨӨ.

Ариун Сүм, Их Эзэний өргөөг үз

ИХ ЭЗЭНИЙ ҮДШИЙН ЗООГ.

Ариун ёслолыг үз

ИХ ЭЗЭНИЙ УСАН ҮЗМИЙН

ТАЛБАЙ. Израил; Талбайг

мөн үз

Сүнсний хөдөлмөрийн талбайн бэлэгдэл. Судруудад Их Эзэний усан үзмийн талбайг ихэнхдээ Израилын угсаа буюу дэлхий дээрх Бурханы хаант улс хэмээдэг. Заримдаа дэлхий дээрх хүмүүсийг ерөнхийд нь хэлдэг.

Түмний Их Эзэний усан үзмийн талбай нь Израилын гэр юм, **Иса.** 5:7 (2 Ниф. 15:7). Есүс усан үзмийн талбайд хөдөлмөрлөгчийн тухай сургаалт зүйрлэлийг өгчээ, **Мат.** 20:1–16. Израил нь Их Эзэний усан үзмийн талбайд ургаж буй гэжээвэр чидуны модтой адил юм, **Иаков** 5. Их Эзэний үйлчлэгчид эцсийн удаа түүний усан үзмийн талбайг тайрах болно, **Иаков** 6. Их Эзэн талбайд хөдөлмөрлөгсдийг адислах болно, **С ба Г** 21:9 (Алма 28:14). Эцсийн удаа миний талбайд хөдөлмөрлө, **С ба Г** 43:28.

ИХЭД ДУРГУЙЦЭХ.

Үзэн ядах,

Үзэн ядалтыг үз

ИШМАЕЛ, АБРАХАМЫН ХҮҮ.

Абрахам, Хейгарыг *мөн үз*

Хуучин Гэрээнд Абрахам Сарагийн египет шивэгчин Хейгар хоёрын хүү (Эхл. 16:11–16). Ишмаелыг агуу их үндэстний эцэг болгохоор Абрахам Хейгар хоёрт хоёуланд нь Их Эзэн амлажээ (Эхл. 21:8–21).

Гэрээ Ишмаелаас илүүгээр Исаакаар дамжин иржээ, **Эхл.** 17:19–21 (Гал. 4:22–5:1). Ишмаелыг өнөр өтгөн, олон хүүхэдтэй болгохоор Бурхан адислав, **Эхл.** 17:20. Абрахамыг оршуулахад Ишмаел туслав, **Эхл.** 25:8–9. Ишмаелын арванхоёр хөвгүүн нэрлэгдэв, **Эхл.** 25:12–16. Ишмаел нас нөгчив, **Эхл.** 25:17–18. Есав Ишмаелын охин Махалатыг эхнэр болгон авав, **Эхл.** 28:9.

ИШМЭИЛ, НИФАЙН ХАДАМ

ЭЦЭГ. Нифайн эцэг Лихайг

мөн үз

Мормоны Номонд Лихайн гэр бүл-

тэй хамт амлагдсан нутгийн зүг хийсэн аян замд нэгдсэн хүн.

Нифай ах нарынхаа хамт Иерусалим уруу буцаж, мөн Ишмэил болон түүний гэр бүлийг Лихай болон түүний гэр бүлийнхний хамт амлагдсан нутгийн зүг явахад нь итгүүлэв, **1 Ниф.** 7:2–5. Хоёр гэр бүлийнхэн хоорондоо гэрлэв, **1 Ниф.** 16:7. Ишмэил аглаг буйдад нас нөгчив, **1 Ниф.** 16:34.

КАИАФ. Аннас; Садукайчуудыг мөн үз

Шинэ Гэрээнд Аннасын хүргэн, дээд санваартан. Каиаф Есүс болон түүний шавь нарыг эсэргүүцэхэд идэвхтэй оролцож байв (Мат. 26:3–4; Иохан 11:47–51; 18:13–14).

КАИН. Абел; Адам; Аллага; Нууц хуйвалдааныг мөн үз

Өөрийн дүү Абелыг алсан Адам Ева хоёрын хүү (Эхл. 4:1–16).

Түүний өргөлийг Их Эзэн хүлээн аваагүй, **Эхл.** 4:3–7 (Мосе 5:5–8, 18–26). Өөрийн дүү Абелыг алсан юм, **Эхл.** 4:8–14 (Мосе 5:32–37). Их Эзэн түүнийг зүхэж мөн тэмдэг тавив, **Эхл.** 4:15 (Мосе 5:37–41). Адам Ева хоёр түүнийг төрөхөөс өмнө олон хөвгүүд охидтой байв, **Мосе** 5:1–3, 16–17. Сатанд Бурханаас илүү хайртай байжээ, **Мосе** 5:13, 18. Сатантай ариун бус гэрээнд орсон ажээ, **Мосе** 5:29–31.

КАЛВАРИ. Голготаг үз

КАЛЕБ

Египетээс гарснаас хойш хоёр жилийн дараа Канааны нутгийг тандуулахаар Мосегоос илгээсэн хүмүүсийн нэг. Тэр, Иошуа хоёр хоёулахнаа газрын үнэн мэдээллийг буцаан авчиржээ (Тоол. 13:6, 30; 14:6–38). Египетэд байсан бүгдээс 40 жил аглаг буйдад тэд хоёулхнаа амьд үлдэж (Тоол. 26:65; 32:12; Дэд хууль 1:36) мөн Канаанд очжээ (Иош. 14:6–14; 15:13–19).

КАНААН, КАНААНЧУУД

Хуучин Гэрээний үеийн Хамын дөрөв дэх хүү (Эхл. 9:22; 10:1, 6) мөн Ноагийн ач хүү. Канаанчууд гэдэг нь Канаан анхлан амьдарч байсан газраас болон мөн түүний үр удамд ирсэн хэн нэгнийг хэлдэг. Канаанчууд гэдэг нь мөн Палестины эрэг Газрын Дундад Тэнгисийн нам дор газар амьдардаг хүмүүсийг нэрлэдэг. Энэ нэр нь заримдаа бүх грекчүүд Фоеник хэмээн нэрлэдэг Иорданы зүүн талын улсад амьдардаг израил бус хүмүүсийг дүрслэхэд хэрэглэгддэг.

КАНОН. Агуу Үнэт Сувд; Библи; Мормоны Ном; Сургаал ба Гэрээ; Судруудыг мөн үз

Хүлээн зөвшөөрөгдсөн, эрх олгогдсон ариун нандин номнуудын цуглуулга. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд каноны номнуудыг жишиг бүтээлүүд хэмээн нэрлэдэг бөгөөд Хуучин ба Шинэ Гэрээ, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ мөн Агуу Үнэт Сувдыг багтаадаг.

КАРТЕЙЖ ШОРОН (АНУ). Бага Иосеф; Смит; Хайрум Смитийг мөн үз

1844 оны зургадугаар сарын 27-нд Америкийн Нэгдсэн Улсын Иллинойн Картейж шоронд Иосеф Смит, Хайрум Смит хоёр бүлэг танхайрагчдад алуулжээ (С ба Г 135).

КАУДЕРИ, ОЛИВЕР

Сэргээгдсэн Сүмийн хоёр дахь аглагч бөгөөд Мормоны Номын бурханлиг гарал үүсэл болон үүний үнэн болохыг гэрчилсэн Гурван гэрчийн нэг. Иосеф Смитийг алтан ялтсуудаас орчуулж байхад тэрээр бичээчээр ажиллаж байв (ИСТ 1:66–68).

Мормоны Номны орчуулгын үнэн болох гэрчлэлийг хүлээн авав, **С ба Г** 6:17, 22–24. Иохан Баптистаар томилогдов, **С ба Г** 13 (С ба Г 27:8; ИОС—Т 1:68–73, 71-р шүлгийн тэмдэглэлийг

үз). Та нар итгэлтэй болж мөн тэдгээрийг нүдээрээ харсны дараа, та нар тэдгээрийн тухай гэрчлэх болно, **С ба Г 17:3, 5**. Чиний бичсэн тэр зүйлүүд үнэн гэдгийг би өөрийн Сүнсээр чамд тунхаглаж байна, **С ба Г 18:2**. Илчлэлтүүдийн дээр даамал байхаар томилогдсдын нэг байжээ, **С ба Г 70:3**. Иосеф Смитийн хамт санваарын түлхүүрүүдыг хүлээн авчээ, **С ба Г 110**.

КИМБАЛЛ, СПЕНСЕР В. Албан

Тунхаг—2-ыг *мөн үз*

1830 онд Сүм үндэслэн байгуулагдсанаас хойших арванхоёр дахь Ерөнхийлөгч. Спенсер В.Кимбалл 1973 оны арванхоёрдугаар сараас 1985 оны арваннэгдүгээр сар хүртэл Ерөнхийлөгчөөр үйлчилж байв. Тэрээр 1895 онд төрж, 1985 онд ерэн настайдаа өөд болжээ.

Зохистой бүх эрэгтэй гишүүдэд санваар болон ариун сүмийн адислалуудыг өргөжүүлэн хүртээх илчлэлт Ерөнхийлөгч Кимбаллаар 1978 оны зургадугаар сард хүлээн авагдсаныг Тэргүүн Зөвлөл зарлажээ, **С ба Г АТ—2**.

КИШКУМЕН. Гаддиантоны

дээрэмчдийг *мөн үз*

Мормоны Номонд, хожим нь Гаддиантоны дээрэмчид хэмээн нэрлэгдсэн бүлэг ёс бус хүмүүсийн удирдагч (**Хил. 1:9–12; 2**).

КОЛОБ

Бурханы хаан сэнтийд хамгийн ойрхон од.

Абрахам Колоб болон однуудыг харав, **Абр. 3:2–18**. Колобын цагийн дагуу Их Эзэний цаг тоологддог, **Абр. 3:4, 9** (**Абр. 5:13**).

КОЛОСАЙЧУУДАД БИЧСЭН

ЗАХИДАЛ. Паул; Паулын захидлуудыг *мөн үз*

Шинэ Гэрээний нэг ном. Анхандаа энэ нь Колосайн Сүмийн сургаал номлогч Епафрагаар зочлогдсоны

хоо дараа колосайчуудад бичсэн Төлөөлөгч Паулын захидал байв (**Кол. 1:7–8**). Колосайчууд ноцтой алдаа гаргаж байсныг тэд зарим гадаад ёслолуудыг анхааралтайгаар сахиж (**Кол. 2:16**), махан биеийн зарим хүслүүдээс өөрсдийгөө татгалзуулж, мөн тэнгэр элчүүдийг шүтэн биширч байсан учир (**Кол. 2:18**) бусад хүмүүсээс илүү дээр гэж боддог байсныг Епафра Паулд ярьжээ. Эдгээр заншлууд өөрсдийгөө ариусгагдсан хэмээн бодоход колосайчуудыг хүргэсэн байв. Түүнчлэн тэд ертөнцийн нууцуудыг Сүмийн бусад гишүүдээс илүү сайн ойлгодог гэж боддог байжээ. Энэ захидалд гэтэлгэл нь зөвхөн Христээр дамжин ирэх бөгөөд бид ухаалаг байж мөн түүнд үйлчлэх ёстой хэмээн Паул тэдний алдааг залуулсан байна.

Бүлэг 1 нь колосайчуудад илгээсэн Паулын мэндчилгээ юм. Бүлэг 2–3 нь номлолын чанартай бөгөөд Христ бол Гэтэлгэгч болох тухай, хуурмаг шүтлэгийн аюул хийгээд амилуулалтын ач холбогдлын талаарх нотолгоонуудыг агуулдаг. Бүлэг 4 нь Гэгээнтнүүд бүх зүйлд ухаалаг байх ёстойг сургадаг.

КОРЕШ

Хуучин Гэрээнд, иудейчүүдийг ариун сүм дахин барихаар Иерусалим уруу буцахыг нь зөвшөөрснөөр Исаиагийн бошиглолыг гүйцэлдүүлж, үүгээрээ Вавилоны боолчлолыг зарим талаар төгсгөл болгосон Персийн хаан (**Шаст. дэд 36:22–23** **Иса. 44:28, 45:1**). Исаиагийн бошиглол хааны энэхүү үйлдлээс 180 жилийн өмнө хийгджээ.

КОРИАНТОН. Алма, Алмагийн

хүүг *мөн үз*

Мормоны Номын Алмагийн хүү болох тэр Алмагийн хүү.

Зорамчууд уруу явав, **Алма 31:7**. Янхан эмийн араас явахаар тохирууллыг орхижээ, **Алма 39:3**. Үхлийн

дараах оршихуйн байдал амилуулалт болон цагаатгалын тухай зааврыг Алма түүнд өгөв, **Алма** 39–42. Дахин номлохоор дуудагдсан, **Алма** 42:31. Умард нутаг тийш усан онгоцоор явав, **Алма** 63:10.

КОРИАНТУМР. Жаредчуудыг
мөн үз

Мормоны Номын жаредчуудын хаан бөгөөд жаред үндэстний хамгийн сүүлчийн амьд үлдсэн хүн.

Зарахемлагийн хүмүүсээр олж мэдэгдсэн байв, **Омнаи** 1:21. Бүх нутгийн дээр хаан байв, **Ифер** 12:1–2. Шаредад олзлогдож мөн түүний хөвгүүдээр чөлөөлөгджээ, **Ифер** 13:23–24. Янз бүрийн дайснуудтай байлдав, **Ифер** 13:28–14:31. Наманчлав, **Ифер** 15:3. Сүүлчийнхээ тулалдааныг Шизтэй хийв, **Ифер** 15:15–32.

КОРИНТЧУУД, ТЭДЭНД
БИЧСЭН ЗАХИДЛУУД. Паул;
Паулын захидлуудыг *мөн үз*

Шинэ Гэрээний хоёр ном. Тэдгээр нь анхандаа эмх замбраагүй байдлыг нь залруулахын тулд Коринтад байсан Гэгээнтнүүдэд Паулын бичсэн захидлууд байв. Коринтчууд ёс суртахууны хувьд ёс бус нийгэмд амьдарч байлаа.

Нэгдүгээр Коринт: Бүлэг 1 нь Паулын мэндчилгээ болон талархлын үгсийг агуулдаг. Бүлэг 2–6-д Коринт дахь Гэгээнтнүүдийн алдааг залруулжээ. Бүлэг 7–12 нь зарим асуултуудад хариулсан Паулын хариултуудыг агуулдаг. Бүлэг 13–15 нь энэрэл, сүнсний бэлгүүд, мөн амилуулалтад хамаатай. Бүлэг 16 нь итгэлдээ үнэнч үлдэх тухай Паулын зөвлөгөөг агуулдаг.

Хоёрдугаар Коринт: Бүлэг 1 нь Паулын мэндчилгээ болон талархлын үгсийг агуулдаг. Бүлэг 2 нь Титэд зориулсан хувийн зөвлөгөөг агуулдаг. Бүлэг 3–7 нь Гэгээнтнүүд болон тэдний удирдагчдын амьдрал дахь сайн мэдээний хүчтэй холбоотой. Бүлэг

8–9-д ядуучуудад баяртайгаар өгөгч байхыг Гэгээнтнүүдэд зөвлөжээ. Бүлэг 10–12-т Паул өөрийгөө Төлөөлөгч гэдгийг нотолсон байдаг. Бүлэг 13 нь төгс болох зөвлөгөө юм.

КОРИХОР. Христийг
эсэргүүцэгчийг *мөн үз*

Бурханы хүчний нотолгоо болгон тэмдгийг шаарддаг байсан, Мормоны Номон дахь Христийг эсэргүүцэгч; Их Эзэн Корихорыг дүлий болгоход хүргэжээ (Алма 30:6–60).

КОРНЕЛ. Зуутын дарга; Петр;
Харийнханыг *мөн үз*

Петрээс баптисм хүртсэн Цезарийн зуутын дарга (Үйлс 10). Магадгүй тэрээр эхлээд Иудейн шашинд хөрвүүлэгдэлгүйгээр Сүмд орсон анхны харь үндэстэн байжээ. Корнел болон түүний гэр бүлийн баптисм нь харийнханд сайн мэдээг номлох замыг нээх тэмдэг болсон байна. Тэр үед дэлхийд Бурханы хаант улсын түлхүүрүүдийг атгадаг байсан ахлах Төлөөлөгч Петр энэ номлолыг удирджээ.

КӨРТЛАНДЫН АРИУН СҮМ

Өнөө үед Сүмийн барьсан анхны ариун сүм. Их Эзэний зарлигийн (С ба Г 94:3–9) дагуу Гэгээнтнүүд Огайогийн Көртландад (Америкийн Нэгдсэн Улс) уг ариун сүмийг барьжээ. Нэг зорилго нь Сүмийн зохистой гишүүд сүнсний хүч, эрх мэдэл хийгээд гэгээрлийг хүлээж авах газрыг бий болгох явдал байлаа (С ба Г 109; 110). Энэ ариун сүм 1836 оны гуравдугаар сарын 27-нд онцгойлон адислагдав; онцгойлон адислах залбирал Бошиглогч Иосеф Смитэд илчлэлтээр өгөгджээ (С ба Г 109). Их Эзэн хэд хэдэн чухал илчлэлтийг өгч, санваарын шаардагдах түлхүүрүүдийг энэ ариун сүмд сэргээжээ (С ба Г 110; 137). Өнөөдөр ариун сүмүүдэд өгөгдсөн ариун сүмийн бүрэн ёслолууд бүрэн ашиглагдаггүй байв.

КУМОРА ГҮВЭЭ. Бага Иосеф

Смит; Мормоны Ном;

Мормоны хүү Моронайг *мөн үз*

Америкийн Нэгдсэн Улсын баруун Нью-Йоркт байдаг жижигхэн гүвээ. Энд эртний бошиглогч Моронай нифайчуудын болон жаредчуудын зарим цэдгийг агуулсан алтан ялтсуудыг нуужээ. 1827 онд Иосеф Смит амилуулагдсан Моронайгаар энэ гүвээг заалган эдгээр ялтсуудыг авч, тэдгээрийн нэг хэсгийг орчуулсан юм. Энэ орчуулга нь Мормоны Ном юм.

Нифайчууд Куморад цугларав, **Морм.** 6:2–4. Кумора олон уснуудын нутаг байв, **Морм.** 6:4. Мормон Кумора гүвээнд цэдгүүдийг нуув, **Морм.** 6:6. Хорин дөрвөн нифай хүнээс бусад нь бүгд Куморад алагдав, **Морм.** 6:11. Бид Куморагаас баярт мэдээг сонсоно, **С ба Г** 128:20. Иосеф Смит Кумора гүвээнээс ялтсуудыг авав, **ИС—Т** 1:42; 50–54, 59.

ЛАБАН, РЕБЕКАГИЙН АХ.Ребекаг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Ребекагийн ах, Иаковын эхнэрүүд Леа, Рахел нарын эцэг (**Эхл.** 24:29–60; 27:43–44; 28:1–5; 29:4–29; 30:25–42; 31:1–55).

ЛАЗАР. Бетанийн Мариа; Мартаг*мөн үз*

Шинэ Гэрээнд, Марта Мариа хоёрын ах. Есүс түүнийг нас барагсдаас босгожээ (**Иохан** 11:1–44; 12:1–2, 9–11). Энэ бол Есүсийн заасан сургаалт зүйрлэл дэх гуйлгачин Лазар биш (**Лук** 16:19–31).

ЛАЦДАХ, ЛАЦДАЛТ. Елиа,Ёслолууд; Санваарыг *мөн үз*

Дэлхий дээр санваарын эрх мэдлээр гүйцэтгэгдсэн ёслолуудыг тэнгэрт хүчинтэй болгох. Ёслолууд нь Ариун Сүнс болох Амлалтын Ариун Сүнсний зөвшөөрөл хүлээн авснаар лацдагддаг.

Дэлхийд та нар юуг ч холболоо гэсэн тэнгэрт холбогдох болно, **Мат.** 16:19

(**Мат.** 18:18; **С ба Г** 124:93; 132:46). Та нар амлалтын Ариун Сүнсээр лацдагдсан болой, **Ефес** 1:13. Та нар дэлхийд юуг ч лацадлаа гэсэн тэнгэрт лацдагдах хүчийг би та нарт өгье, **Хил.** 10:7. Дэлхий хийгээд тэнгэрт аль алинд нь лацдах хүч тэдэнд өгөгдсөн билээ, **С ба Г** 1:8. Селестиел алдар суун дахь тэд Амлалтын Ариун Сүнсээр лацдагдсан билээ, **С ба Г** 76:50–70. Елиа Иосеф Смитийн гарт лацдах хүчний тулхүүрүүдийг даатгасан болгоо, **С ба Г** 110:13–16. Энэ бол лацдах хийгээд холбох хүч, **С ба Г** 128:14. Бошиголын өөр үг бол мөнх амьдралд лацдагдсанаа мэдэх нь болой, **С ба Г** 131:5. Амлалтын Ариун Сүнсээр лацдагдаагүй бүх гэрээ хүмүүсийг нас барахад төгсгөл болдог, **С ба Г** 132:7. Ариун сүнснүүдэд хийгдэх ёстой агуу ажил нь хүүхдүүдийг эцэг эхчүүдтэй нь лацдан холбохыг багтаадаг, **С ба Г** 138:47–48.

ЛЕА. Иаков, Исаакийн хүү;Лабан, Ребекагийн ахыг *мөн үз*

Шинэ Гэрээнд, Лабаны ууган охин, Иаковын эхнэрүүдийн нэг (**Эхл.** 29). Леа зургаан хүү, нэг охины эх болжээ (**Эхл.** 29:31–35; 30:17–21).

ЛЕБЕН, ГУУЛИН ЯЛТСУУДЫГ**ХАДГАЛАГЧ.** Гуулинялтсуудыг *мөн үз*

Мормоны Номонд, Лихайн гэр бүлийн үед гуулин ялтсуудыг Иерусалимд хадгалж байсан хүн. Нифай болон түүний ах нарыг Лебен дээрэмдэж, алахаар оролдож байв (1 **Ниф.** 3:1–27). Ялтсуудыг авахын тулд Лебенийг алахад Нифайг Сүнс удирджээ (1 **Ниф.** 4:1–26).

ЛЕВИ. Израил; Исаакийн хүүИаковыг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Иаков Леа хоёрын гурав дахь хүү (**Эхл.** 29:34; 35:23). Леви Израилын овгуудын нэгнийх нь эцэг болжээ.

Левийн овог: Леви болон түүний үр удмынхныг Иаков адисалжээ (**Эхл.**

49:5–7). Левийн удмынхан Израилын ариун дугануудад тохинуулдаг байв (Тоол. 1:47–54). Аарон бол леви хүн байсан бөгөөд түүний үр удмынхан санваартнууд байв (Ег. 6:16–20; 28:1–4; 29). Санваартнууд түүнчлэн Аароны хөвгүүдэд левичүүд тусалдаг байлаа (Тоол. 3:5–10; Хаад. дээд 8:4). Зарим үед тэд хөгжимчид болж (Шаст. дээд 15:16; Нех. 11:22); тахилын малыг нядалж (Шаст. дэд 29:34; Езра 6:20); ерөнхийдөө ариун сүмд тусалдаг байв (Нех. 11:16). Левичүүд Израилын хүүхдүүдийн төлөө ёслолуудыг гүйцэтгэх Их Эзэний үйлчлэлд онцгойлон адислагдсан байв. Левичүүд Израилын хүүхдүүдийн өмнөөс өөрсдийгөө зориулахаар санал болгосон билээ (Тоол. 8:11–22); ийнхүү тэд Бурханы онцгой өмч болж, ууган төрсний байрыг эзлэхээр түүнд өгөгджээ (Тоол. 8:16). Тэд өргөл болгогдоогүй хэдий ч, өөрсдийнхөө албан тушаалын тулд цэвэршүүлэгдсэн байлаа (Тоол. 8:7–16). Тэд Канаанд өвийн нутаггүй байсан ч (Тоол. 18:23–24), тэд аравны нэг (Тоол. 18:21), дөчин найман хот (Тоол. 35:6) хүлээн авч, түүнчлэн найрын үед хүмүүсээс өглөг хүлээн авах эрхтэй байжээ (Дэд хууль 12:18–19; 14:27–29).

ЛЕВИЙН САНВААР. Аароны санваарыг үз

ЛЕВИТ. Пентатеухыг мөн үз

Израил дахь санваарын үүргүүдийн тухай өгүүлдэг Хуучин Гэрээний нэг ном. Энэ ном Бурханы ариун чанар хийгээд түүний хүмүүс ариун болохын тулд сахиж амьдрах ёстой хуулинд онцгой анхаарал тавьдаг. Үүний зорилго нь ёс суртахууны дүрэм зааврууд хийгээд Мосегийн хуулийн шашны үнэнүүдийг зан үйлийн аргаар заах явдал юм. Левитийн номыг Мосе бичжээ.

Бүлэг 1–7 нь тахилын зан үйлүүдийг тайлбарладаг. Бүлэг 8–10 нь санваартнуудын ариун зан адислалтад баримталдаг асан зан үйлийг

дүрсэлдэг. Бүлэг 11 нь юуг идэж болох хийгээд болохгүйг, түүнчлэн юу цэвэр хийгээд цэвэр бусыг тайлбарладаг. Бүлэг 12 нь хүүхэд төрүүлсний дараах эмэгтэйчүүдийн тухай өгүүлдэг. Бүлэг 13–15 нь ёслолын ариун бус байдалд холбогдох хуулиуд юм. Бүлэг 16 нь Цагаатгалын Өдөр баримтлах ёстой зан үйлийг агуулдаг. Бүлэг 17–26 нь шашны хийгээд нийгмийн талаар баримталдаг зүйлүүдэд холбогдох хуулиудын товъёогийг агуулдаг. Бүлэг 27 нь өөрсдийнхөө үр тариа, сүрэг, малаа Их Эзэнд өргөл болгон өгөхийг Их Эзэн зарлигласан тухай тайлбарладаг.

ЛЕМЕН. Леменчүүд; Нифайн эцэг Лихайг мөн үз

Мормоны Номонд Лихай, Сариа хоёрын ууган хүү, Нифайн хамгийн том ах (1 Ниф. 2:5). Ерөнхийдөө Лемен сайны оронд хилэнцтийг хийхээр сонгожээ.

Лемен эцгийнхээ эсрэг бувтнав, **1 Ниф.** 2:11–12. Зөв шударга дүү Нифайгаа эсэргүүцэв, **1 Ниф.** 7:6 (1 Ниф. 3:28–29). Лихайн үзэгдэл дэх модны жимснээс хүртсэнгүй, **1 Ниф.** 8:35–36. Лемен болон түүний дагалдагчид дээр зүхэл ирэв, **2 Ниф.** 5:21 (Алма 3:7).

ЛИАХОНА

Мормоны Номонд, зүг чиг заадаг, мөн түүнчлэн Лихай болон түүнийг дагалдагчдад сүнсний заавар өгдөг хоёр зүү бүхий луужинтай төстэй ээс бөмбөрцөг. Их Эзэн лиахонагаар хангаж, түүнчлэн үүгээр дамжуулан заавар өгдөг байжээ.

Лихай болон түүний гэр бүлд хаашаа явах замыг нь заадаг хоёр зүү бүхий ээс бөмбөрцгийг Лихай олов, **1 Ниф.** 16:10. Итгэл хийгээд хичээл зүтгэлийн дагуу бөмбөрцөг ажилладаг байв, **1 Ниф.** 16:28–29 (Алма 37:40). Бенжамин бөмбөрцгийг Мозаяд өгчээ, **Моз.** 1:16. Уг бөмбөрцөг букуу зүг чиг заагчийг лиахона гэдэг байв, **Алма** 37:38. Лиакхона Христийн үгтэй

харьцуулагддаг байв, **Алма** 37:43–45. **Мормоны Номын Гурван** гэрч, **Лихайд** өгөгдсөн зүг чиг заагчийг харах болно, **С ба Г** 17:1.

ЛИБЕРТИЙН ШОРОН,
МИССУРИ (АНУ). Бага Иосеф
Смитийг мөн үз

Бошиглогч Иосеф Смит болон бусад хүмүүс 1838 оны арваннэгдүгээр сараас 1839 оны дөрөвдүгээр сар хүртэл шударга бусаар хоригдож байсан жижиг шорон. Эдгээр хүнд хэцүү нөхцөл байдалд Иосеф зарим илчлэлтүүд хүлээн авч, бошиглолууд өгч, түүнчлэн Сургаал ба Гэрээ 121–123-т цуврал хэсгүүд нь агуулагддаг чухал захидлыг Гэ гээнтнүүдэд бичжээ.

ЛИМХАЙ. Зенифийн хүү Ноаг
мөн үз

Мормоны Номонд, **Нифайн** нутаг дахь нифайчуудын зөв шударга хаан; тэр бол Хаан Ноагийн хүү байлаа (**Моз.** 7:7–9). Хаан Лимхай Бурланд үйлчлэх гэрээнд оржээ (**Моз.** 21:32). Тэрээр өөрийн хүмүүсийг леменчүүдийн боолчлолоос удирдан гаргаж Зарахемлад эргэж иржээ (**Моз.** 22).

ЛИХАЙ, НИФАЙН ЭЦЭГ

Мормоны Номонд, мээ 600 оны үед өөрийн гэр бүл болон дагалдагсдыг Иерусалимаас дэлхийн бөмбөрцгийн баруун хагас дахь амлагдсан нутгийн зүг удирдсан еврей бошиглогч. Мормоны Номон дахь өөрийнхөө хүмүүсийн дунд Лихай анхны бошиглогч байв.

Их Эзэний зарлигаар Лихай гэр бүлийнхээ хамт Иерусалимаас зугтжээ (1 **Ниф.** 2:1–4). Тэр бол Египетэд худалдагдсан Иосефын удам байв (1 **Ниф.** 5:14). Амьдралын модны тухай үзэгдлийг Их Эзэн түүнд өгчээ (1 **Ниф.** 8:2–35). Лихай болон түүний хөвгүүд хөлөг онгоц барьж дэлхийн баруун хагас уруу хөвжээ (1 **Ниф.** 17–18). Тэр болон түүний үр

удмынхан шинэ газарт суурьшив (1 **Ниф.** 18:23–25). Лихай нас барахынхаа өмнө хөвгүүдээ адисалж, Христийн тухай, түүнчлэн хожмын өдрүүдэд Мормоны Ном урагш гарч ирэх тухай тэдэнд заав (2 **Ниф.** 1–3, 4:1–12).

Лихайн ном: Иосеф Смит Мормоны Номыг орчуулахдаа Лихайн номноос эхэлжээ. Энэ бол Лихайн ялтсуудаас Мормоны хураангуйлсан цэдэг байв. Тэрээр энэ номноос 116 хуудсыг гар бичмэлээр орчуулсны дараа, Мормоны Номны орчуулгад богино хугацаагаар бичээчээр үйлчилж байсан Мартин Харрист гар бичмэлийг өгчээ. Ингээд уг хуудсууд алга болсон байна. Иосеф алга болсон гар бичмэлийг орлуулахын тулд Лихайн номыг дахин орчуулсангүй, харин оронд нь алтан ялтсуудаас холбогдох бусад шастируудыг орчуулжээ (**С ба Г** 3, 10-ын оршлуудыг үз). Эдгээр бусад шастирууд нь эдүгээ Мормоны Номны эхний зургаан ном юм.

ЛИХАЙ, НИФАЙЧУУДЫН
НОМЛОГЧ. Хиламан,
Хиламаны хүүг мөн үз

Мормоны Номонд, Хиламаны хүү асан Хиламан. Лихай агуу номлогч байв (**Хил.** 3:21; 4:14).

Өвөг дээдсийг нь сануулахын тулд Лихай хэмээн нэрлэгдэв, **Хил.** 5:4–6. Нифайн хамт олон хөрвөгдөгч шоронд хоригдож, галаар хүрээлэгдэж, мөн тэнгэр элчүүдтэй ярив, **Хил.** 5:14–48. Өдөр бүр олон илчлэлт хүлээн авч байв, **Хил.** 11:23.

ЛИХАЙ, НИФАЙЧУУДЫН
ЦЭРГИЙН ЖАНЖИН

Мормоны Номонд нифайчуудын цэргийн жанжин (**Алма** 43:35–53; 49:16–17; 52:27–36; 53:2; 61:15–21).

ЛОТ. Абрахамыг мөн үз

Хуучин Гэрээнд, Хараны хүү, Абрахамын ач (**Эхл.** 11:27, 31; **Абр.** 2:4). Урт болсон өлсгөлөнгийн улмаас

Харан нас баржээ (Абр. 2:1). Лот Абрахам Сара хоёртой хамт Урыг орхин, мөн тэдэнтэй хамт Канаан уруу явав (Эхл. 12:4–5). Лот Содомд амьдрахаар сонгожээ. Хүмүүсийнх нь ёсон бусын улмаас Их Эзэн энэ хотыг устгахын өмнө Содомоос зугтахыг Лотод сануулахаар Их Эзэн элчүүдийг илгээсэн (Эхл. 13:8–13; 19:1; 13, 15) хэдий ч, Лотын эхнэр устгал уруу эргэж хараад, давсан багана болжээ (Эхл. 19:26). Шинэ Гэрээ Лотын талаар ишлэлүүдийг агуулдаг (Лук, 17:29; 2 Петр 2:6–7). Абрахамаас тусгаарласных нь дараах түүний амьдралыг Эхлэл 13, 14 мөн 19-д дүрсэлсэн байдаг.

ЛУК. Сайн Мэдээнүүд;

Төлөөлөгчдийн үйлсийг *мөн үз*

Шинэ Гэрээн дэх Лукийн Сайн мэдээний болон Үйлсийн номны зохиогч, түүнчлэн Паулын номлолын хамтрагч. Тэрээр грек эцэг эхийн гэр бүлд төрсөн бөгөөд анагаах ухаанаар ажиллаж байв (Кол. 4:14). Лук сайн боловсролтой байжээ. Тэрээр Тройд Паултай нэгдсэн үедээ өөрийгөө Төлөөлөгч Паулын хамтрагч болохыг ойлгосон байна (Үйлс 16:10–11). Түүнчлэн Лук Иерусалим уруу хийсэн Паулын сүүлчийн аялалд Паултай хамт Филиппойд очиж (Үйлс 20:6), мөн тэр хоёр Ромд иртлээ хамт байжээ. Лук Паулыг хоёр дахь удаагаа Ромд шоронд хоригдох үеэр түүнтэй хамт байлаа (2 Тим. 4:11). Ам дамжсан яриагаар бол тэрээр итгэлийнхээ учир алагджээ.

Лукийн Сайн мэдээ: Есүс Христ болон түүний мөнх бус байдлын тохинууллын тухай Лукийн бичсэн шастир. Төлөөлөгчдийн Үйлсийн тухай ном бол Лукийн сайн мэдээний үргэлжлэл мөн. Есүс бол иудейчүүд ба харийнхан аль алиных нь Аврагч болохыг толилуулан Есүсийн тохинууллын тухай сайн бичигдсэн шастирыг Лук үлдээсэн юм. Тэрээр Есүсийн сургаалууд хийгээд ажил үйлсийн талаар ихийг бичсэн юм. Захариа, Мариа нар дээр Габриел

хүрч ирсэн тухай (Лук 1); хоньчид нярай Есүс дээр ирсэн тухай (Лук 2:8–18); Есүс арванхоёр настайдаа ариун сүмд очсоныг (Лук 2:41–52); үүрэг хүлээж, илгээгдсэн далын тухай (Лук 10:1–24); цус нь шүүрч асан Есүсийн тухай (Лук 22:44); загалмай дээрх хулгайчтай Есүс ярилцсан тухай (Лук 23:39–43); түүнчлэн амилалтын дараа загас, зөгийн бал идэж байсан Есүсийн тухай (Лук 24:42–43) шастируудыг бид гагцхүү Лукаас олж хардаг.

Бүлгийн тоймыг Сайн Мэдээнүүдээс үз.

ЛЕМЕНЧҮҮД. Лемен; Мормоны

Ном; Нифайчуудыг *мөн үз*

Тэднээс олон нь Лихайн ууган хүү Лемений үр удмынхан байсан, Мормоны Номон дахь бүлэг хүмүүс. Тэд Нифай болон түүний үр удмынхан өөрсдийг нь буруу замаар удирдаж байна хэмээн боддог байв (Моз. 10:11–17). Тэд нифайчуудын эсрэг босч, сайн мэдээний сургаалуудыг олонтаа эсэргүүцдэг байв. Гэвч Есүс Христийг төрөхийн өмнөхөн леменчүүд сайн мэдээг хүлээн зөвшөөрч нифайчуудаас ч илүү зөв шударга байв (Хил. 6:34–36). Христ Америкт очсоноос хойш хоёр зуун жилийн дараа леменчүүд нифайчууд аль аль нь ёс бус болж, бие биенийхээ эсрэг дайтаж эхлэв. мэ 400 оны орчимд леменчүүд нифай үндэстнийг бүрмөсөн устгажээ.

Леменчүүд Нифайн үр удмыг ялан дийлэв, **1 Ниф.** 12:19–20. Леменчүүд нифайчуудыг үзэн яддаг байв, **2 Ниф.** 5:14. Леменчүүд нифайчуудад зовлон учруулах болно, **2 Ниф.** 5:25. Мормоны Ном өвөг дээдсийнх нь тухай болон Есүс Христийн сайн мэдээний тухай мэдлэгийг леменчүүдэд сэргээх болно, **2 Ниф.** 30:3–6 (Мормоны Номын эхний хуудас). Лэмэнчүүд бол иудейчүүдийн үлдэгдэл мөн, **С ба Г** 19:27. Их Эзэний ирэлтийн өмнө леменчүүд сарнай лугаа адил цэцэглэн хөгжих болно, **С ба Г** 49:24.

ЛЕМОНАЙ. Мозаягийн хүү

Аммоныг мөн үз

Мормоны Номонд, Их Эзэний Сүнсээр, мөн сүнсний нөлөөллөөр хийсэн Аммоны хөдөлмөр хийгээд сургаалуудын улмаас хөрвүүлэгдсэн леменчүүдийн хаан (Алма 17–19).

ЛЕМУЕЛ. Лемен; Леменчүүд;

Нифайн эцэг Лихайг мөн үз

Мормоны Номонд, Лихайн хоёр дахь хүү, Нифайн ах нарын нэг. Тэрээр Нифайг эсэргүүцэхээр Лементэй нийлжээ.

Хөндий мэт тууштай байхыг Лихай Лемүелд сануулав, **1 Ниф.** 2:10. Нифайд уурлаж, тэгээд Леменийг анхаарав, **1 Ниф.** 3:28. Лемүелчүүд Леменчүүдийн дунд орсон байв, **Иаков** 1:13–14 (Алма 47:35).

ЛЮСИФЕР. Мөхлийн хүүхдүүд;

Там; Устгагч; Христийг эсэргүүцэгч; Чөтгөрийг мөн үз

Уг нэр нь Гялалзагч нэгэн буюу Гэрэл авч явагч гэсэн утгатай. Тэрээр бас Өглөөний хүү хэмээн нэрлэгддэг. Люсифер бол Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүү байсан бөгөөд мөнх бус байдлын өмнөх үед бослогод удирджээ. Люсифер гэдэг нэр Библид ердөө ганцхан удаа гардаг (Иса. 14:12). Хожмын үеийн илчлэлт Люсиферийн уналтын талаар тодорхой зүйл агуулсан байдаг (С ба Г 76:25–29).

Люсифер мөнх бус амьдралын өмнөх амьдралд унасан, **Иса.** 14:12 (Лук 10:18; 2 Ниф. 24:12). Унасныхаа дараа тэрээр Сатан мөн чөтгөр болсон, **С ба Г** 76:25–29 (Моце 4:1–4).

МАГОГ. Гог; Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийг мөн үз

Библид, Хар Далайн ойролцоох нутаг болон хүмүүс. Христийн хоёр дахь ирэлтийн өмнө тэдний хаан Гог Магогийн их цэргийг сүүлчийн агуу тулалдаанд удирдах болно (Езек. 38:2; 39:6). Мянган жилийн төгсгөлд Гог болон Магогийн, мөн

Бурханы хүчнүүд хийгээд хилэнцэт хүчнүүдийн хоорондох өөр нэг агуу тулалдааны тухай судрууд өгүүлсэн байдаг (Илч. 20:7–9; С ба Г 88:111–116).

МАГТААЛ. Алдар суу;

Талархалтай; Талархал; Талархал илэрхийлэхийг үз

МАЛАХИ

Ойролцоогоор мээ 430 оны үед бичиж мөн бошиглож асан Хуучин Гэрээний бошиглогч.

Малахийн ном: Малахийн ном буюу бошиглол нь Хуучин Гэрээний сүүлчийн ном юм. Уг ном дөрвөн үндсэн гол сэдвийг хамардаг: (1) Израилын нүглүүд—Малахи 1:6–2:17; 3:8–9; (2) тэдний дуулгаваргүйн улмаас Израил дээр ирэх шүүлтүүд—Малахи 1:14; 2:2–3, 12; 3:5; (3) дуулгавартай байдлын төлөөх адислалууд—Малахи 3:10–12, 16–18; 4:2–3; болон Израилд хамаарах бошиглолууд—Малахи 3:1–5; 4:1, 5–6, (С ба Г 2; 128:17; ИС—Т 1:37–39).

Малахи өөрийн бошиглолд Иохан Баптистын тухай (Малах. 3:1; Мат. 11:10), аравны нэгийн хууль (Малах. 3:7–12), Их Эзэний хоёр дахь ирэлт (Малах. 4:5) түүнчлэн Елиагийн эргэн ирэлтийн тухай (Малах. 4:5–6; С ба Г 2; 128:17; ИС—Т 1:37–39) бичсэн байдаг. Малахийн бүх бүлэгт түүнчлэн 3 ба 4 Нифайд Аврагч (3 Ниф. 24–25) дурдагдсан байдаг.

МАММОН. Мөнгийг мөн үз

“Баялгууд” гэсэн утгатай арамей үг (Мат. 6:24; Лук 16:9; С ба Г 82:22).

МАНАССЕ. Ефраим; Иаковын хүүг, Иосеф; Израилыг мөн үз

Хуучин Гэрээнд, Асенат Иосеф хоёрын, Египетэд худалдагдсан ууган хүү (Эхл. 41:50–51). Тэр болон түүний дүү Ефраим хоёр Иаковын (Израил) ач нар байсан хэдий ч, тэрээр тэднийг яг өөрийнхөө хөвгүүдийн адилаар үрчлэн авч, адисалжээ (Эхл. 48:1–20).

Манассегийн овог: Манассегийн үр удам Израилын овгуудын дунд тоологддог байв (Тоол. 1:34–35; Иош. 13:29–31). Иосефын овгийг адисалсан Мосегийн адислал мөн тэрчлэн Ефраим болон Манассед өгөгдсөнийг Дэд Хуулийн 33:13–17-д цэдэглэсэн байдаг. Тэдэнд ноогдсон нутаг нь Ефраимын залгаах Иорданы баруун хэсэгт байжээ. Тэд түүнчлэн Иорданы зүүнтээ Башан болон Гилеадын үржил шимт билчээрийн газрыг эзэмшиж байв. Эцсийн өдрүүдэд, Манассегийн овог, тарж бутарсан Израилыг цуглуулахад Ефраимын овогт туслах болно (Дэд хууль 33:13–17). Мормоны Номын бошиглогч Лихай Манассегийн удам байв (Алма 10:3).

МАННА. Амьдралын талх;

Египетээс Гарсаныг мөн үз

Шингэн зөгийн бал, эсвэл шинэхэн тосны (Тоол. 11:8) амттай, сэвсгэр цагаан, тэжээлийн бодис (Ег. 16:14–31). Цөлд байсан дөчин жилийнх нь туршид Израилын хүүхдүүдийг хооллохын тулд Их Эзэн үүнийг өгчээ (Ег. 16:4–5, 14–30, 35 Иош. 5:12 1 Ниф. 17:28).

Израилын хүүхдүүд үүнийг манна (Еврей хэлээр ман-ху буюу “Энэ юу вэ? ”) хэмээн нэрлэдэг байв— учир нь тэд энэ зүйл юу болохыг мэддэггүй байжээ (Ег. 16:15). Үүнийг мөн “тэнгэр элчийн хүнс”, түүнчлэн “тэнгэрийн талх” хэмээн нэрлэдэг байв (Дуул. 78:24–25; Иохан 6:31). Энэ нь амьдралын талх болох байсан Христийн бэлэгдэл байлаа (Иохан 6:31–35).

МАРИА, БЕТАНИЙН. Лазар;

Мартаг мөн үз

Шинэ Гэрээнд гардаг Лазар Марта хоёрын дүү.

Мариа Есүсийн хөлд суугаад үгийг нь сонсож байлаа, **Лук** 10:39, 42. Мариа болон түүний эгч Марта нар Есүст хүн явуулжээ, **Иохан** 11:1–45. Тэр Есүсийн хөлийг тосоор тосолжээ, **Иохан** 12:3–8.

МАРИА, ЕСҮСИЙН ЭХ. Есүс

Христ; Мариагийн нөхөр

Иосефыг мөн үз

Шинэ Гэрээнд, Өөрийн Хүүгийн махбодийн эх байлगाхаар Бурхан Эцэгээр сонгогдсон онгон бүсгүй. Есүсийг мэндэлсний дараа Мариа өөр хүүхдүүдтэй болжээ (Марк 6:3).

Тэрээр Иосефтай сүй тавьсан байлаа, **Мат.** 1:18 (Лук 1:27). Мариагаас салах буюу сүйг цуцлахгүй байхыг Иосефт хэлжээ, **Мат.** 1:18–25. Мэргэн хүмүүс Мариа дээр ирэв, **Мат.** 2:11. Мариа Иосеф хоёр бяцхан хүүхдийн хамт Египет уруу зугтав, **Мат.** 2:13–14. Херодыг нас барсны дараа, гэрээрээ Назарт эргэж ирэв, **Мат.** 2:19–23. Тэнгэр элч Габриел түүн дээр хүрч ирэв, **Лук** 1:26–38. Тэрээр өөрийн үеэл эгч Елизабеттай очиж уулзав, **Лук** 1:36, 40–45. Мариа Их Эзэнд магтаалын дуун өргөв, **Лук** 1:46–55. Мариа Иосефын хамт Бетлехем уруу явав, **Лук** 2:4–5. Мариа Есүсийг төрүүлж, тэжээлийн тэвшин дотор тавив, **Лук** 2:7. Хоньчид Христ хүүг олж харахаар Бетлехем уруу явцгаав, **Лук** 2:16–20. Мариа, Иосеф хоёр Есүсийг Иерусалимын ариун сүмд аваачив, **Лук** 2:21–38. Мариа, Иосеф хоёр Есүсийг Дээгүүр өнгөрсний баярт аваачив, **Лук** 2:41–52. Кана хотод болсон нэг хуриманд Мариа байв, **Иохан** 2:2–5. Аврагч загалмай дээр байхдаа, ээждээ анхаарал халамж тавьж байхыг Иоханаас хүсчээ, **Иохан** 19:25–27. Христийг тэнгэрт аваачигдсаны дараа Мариа Төлөөлөгчидтэй хамт байв, **Үйлс** 1:14. Мариа үлэмж үзэсгэлэн гоо, бусад бүх онгон бүсгүйчүүдээс хамгийн хонгорхон цагаан, онгон бүсгүй байлаа, **1 Ниф.** 11:13–20. Христийн эхийг Мариа хэмээн нэрлэдэг байв, **Моз.** 3:8. Мариа бол үнэ цэнэтэй хийгээд сонгогдсон тээгч, онгон бүсгүй байх болно, **Алма** 7:10.

МАРИА, МАГДАЛЫН

Шинэ Гэрээнд Есүс Христийн чин үнэнч шавь байсан эмэгтэй. Энэхүү

Мариа нутгаараа Магдалын хэмээн нэрлэгддэг байжээ. Энэ газар Галилын тэнгисийн баруун эрэгт байдаг байв.

Тэр эмэгтэй загалмайн дэргэд байв, **Мат.** 27:56 (Марк 15:40; Иохан 19:25). Тэр Христийн булшны эсрэг талд сууж байв, **Мат.** 27:61 (Марк 15:47). Тэрээр амилалтын өглөө булшийг үзэхээр ирэв, **Мат.** 28:1 (Марк 16:1; Лук 24:10; Иохан 20:1, 11). Есүс амилалтынхаа дараа хамгийн түрүүнд түүн дээр хүрч иржээ, **Марк** 16:9 (Иохан 20:14–18). Долоон чөтгөр түүнээс салан явав, **Лук** 8:2.

МАРИА, МАРКИЙН ЭХ.

Маркийг *мөн үз*

Шинэ Гэрээнд, Маркийн Сайн мэдээг бичсэн Иохан Маркийн эх (Үйлс 12:12).

МАРК. Сайн Мэдээнүүдийг *мөн үз*

Шинэ Гэрээнд Иохан Марк нь Иерусалимд амьдарч асан Мариагийн хүү байв (Үйлс 12:12); тэрбээр түүнчлэн Барнабын үеэл (эсвэл ач хүү) байж болох талтай (Кол. 4:10). Тэрээр Паул Барнаб хоёртой хамт Иерусалимаас, анхныхаа номлолын аянд гарч, тэднийг Пергад орхижээ (Үйлс 12:25; 13:5, 13). Хожим нь тэрээр Кипр уруу Барнабыг дагалдан явжээ (Үйлс 15:37–39). Тэрээр Ромд Паулын хамт байжээ (Кол. 4:10; Филип. 1:24); мөн тэрээр Петртэй хамт Вавилонд (Ромд мөн байсан бололтой) байв (1 Петр 5:13). Эцэст нь тэрээр Тимоттай хамт Ефест байжээ (2 Тим. 4:11).

Маркийн Сайн мэдээ: Шинэ Гэрээний хоёр дахь ном. Маркийн сайн мэдээ нь Петрийн удирдлага дор бичигдсэн байж магадгүй. Түүний зорилго бол хүмүүсийн дунд амьдарч, үйл ажиллагаа явуулж байсан Бурханы Хүү, Их Эзэнийг дүрслэн харуулах явдал байлаа. Гэрчлэгчдэд Есүсийн төрүүлдэг байсан сэтгэгдлийг эрч хүч хийгээд даруу байдлаар Марк дүрслэн харуулсан байдаг. Ам дамжсан яриагаар бол Петрийг

нас барсны дараа Марк Египетэд очиж, Александрт Сүм байгуулан, дараа нь алагджээ.

Бүлгийн тойм болгон, “Сайн Мэдээнүүдийг” үз.

МАРТА. Бетанийн Мариа;

Лазарыг *мөн үз*

Шинэ Гэрээнд гардаг Лазар Мариа хоёрын эгч (Лук 10:38–42; Иохан 11:1–46; 12:2).

МАРШ, ТОМАС Б.

1830 онд Сүмийг сэргээсний дараах Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын анхны ерөнхийлөгч. Арванхоёрт хамаарах хаант улсын түлхүүрүүдийг тэрээр атгаж байв (С ба Г 112:16), мөн 1838 онд Их Эзэний үгийг хэвлэхээр илчлэлтээр зарлигдуулжээ (С ба Г 118:2). Сургаал ба Гэрээний хэсэг 31 нь түүнд чиглэгдсэн юм. Марш 1839 онд Сүмээс хөөгдсөн боловч 1857 онд дахин баптисм хүртжээ.

МАТАЙ. Сайн Мэдээнүүдийг

мөн үз

Шинэ Гэрээний анхны номны зохиогч мөн Есүс Христийн Төлөөлөгч. Капернаумд ромчуудын татвар хураагч байсан иудей үндэстэн Матай Херод Антипын үйлчлэлд байсан бололтой. Алфайн хүү Леви хэмээн хөрвүүлэгдэхээс нь өмнө түүнийг мэддэг байжээ (Марк 2:14). Тэрээр Есүсийн шавь болж дуудагдсаныхаа дараа удалгүй найр хийж, тэнд Их Эзэн байжээ (Мат. 9:9–13; Марк 2:14–17; Лук 5:27–32). Матай Хуучин Гэрээний судруудын талаар өргөн мэдлэгтэй байж, Их Эзэний амьдралын талаарх бошиглолын биелэлтийг нарийн тодорхойгоор харах чадвартай байсан бололтой. Энэ төлөөлөгчийн хожмын амьдралын талаар нэн бага зүйл мэдэгдэж байгаа болно. Ам дамжсан яриагаар бол тэрээр алагджээ.

Матайн Сайн мэдээ: Шинэ Гэрээний анхны ном. Матайн Сайн мэдээ анхны үед Палестин дахь иудейчүүд

түүнийг ашиглахын тулд бичигдсэн байж болох магадлалтай. Матайн үндсэн гол сэдэв нь Хуучин Гэрээний бошиглогчдын өгүүлдэг байсан Мессиа бол Есүс Христ мөн гэдгийг харуулах явдал байв. Тэрбээр тэрчлэн Есүс бол хүмүүний Хаан хийгээд Шүүгч мөн гэдгийг онцлон тэмдэглэдэг байв.

Бүлгийн тойм болгон, “Сайн Мэдээнүүдийг” үз.

МАТТИА. Төлөөлөгч —

Төлөөлөгчдийг сонгохыг *мөн үз*

Искаротын Иудасын оронд Арванхоёр Төлөөлөгчийн гишүүнээр сонгогдсон хүн (Үйлс 1:15–26). Есүсийн мөнх бус тохинууллын бүхий л үед тэрээр шавь нь байв (Үйлс 1:21–22).

МАХ, МАХАНБОДЬ. Зуурдын

Бие; Мөнх бус, Мөнх бус байдал; Эгэл хүнийг *мөн үз*

Мах, маханбодь нь хэд хэдэн утгатай; 1) Хүн, амьтан, шувуу буюу загасны биеийг бүрдүүлдэг зөөлөн эд; 2) Мөнх бус байдал; түүнчлэн 3) Хүний бие бялдар буюу төрөлхийн мөн чанар.

Биеийн эд: Амьтад та нарын хоол хүнс байх болно, **Эхл.** 9:3. Амьтдыг шаардлагагүйгээр алах ёсгүй, **ИСО, Эх.** 9:10–11 (С ба Г 49:21). Амьтад хийгээд шувууд нь хүмүүний тулд ирэх хийгээд хувцас хунар болгон ашиглахын тулд байдаг, **С ба Г** 49:18–19 (С ба Г 59:16–20). Бид махыг хэмнэлтэйгээр идэх ёстой, **С ба Г** 89:12–15.

Мөнх бус байдал: Есүс бол мөнх бус байдалд Эцэгт Төрсөн Ганц нь билээ, **Иохан** 1:14 (Моз. 15:1–3). Адам бол анхны маханбодь байв, **Моисе** 3:7.

Хүний төрөлхийн мөн чанар: Бие махбодио өөрийн хүч чадал болгодог хүн зүхэгдсэн билээ, **Иер.** 17:5. Сүнс нь хүсч байна, харин махан бие сул дорой байна, **Марк** 14:38. Махан биеийн хүсэл тачаал нь Эцэгээс бус юм, **1 Иохан** 2:16. Өөрийн махан бие хийгээд алдсуудын учир Нифай

харуусч байв, **2 Ниф.** 4:17–18, 34. Чөтгөрийн болон махан биеийн таашаалд өөрсдийгөө бүү нийцүүл, **2 Ниф.** 10:24.

МАЦАГ, МАЦАГ БАРИХ. Өглөг,

Өглөг өгөх; Өргөл; Халамж; Ядуусыг *мөн үз*

Их Эзэнд илүү ойр байж, түүний адислалуудыг хүсэх зорилгоор идэх уухаас сайн дураараа түдгэлзэх. Хувь хүмүүс болон хэсэг бүлгээрээ мацаг барих үед тэд түүнчлэн Бурханы тааллыг ойлгож, сүнслэг хүч чадлыг илүү хөгжүүлэхээр залбирах хэрэгтэй. Үнэн итгэгчид үргэлж мацаг барьдаг билээ.

Өнөөдөр Сүмд сар бүр нэг Хүндэтгэлийн өдрийг мацаг барихад зориулдаг. Энэ үед Сүмийн гишүүд хорин дөрвөн цаг хоол ундгүй байдаг. Тэгээд тэд хоол унданд зориулах ёстой байсан мөнгөө Сүмд хандивладаг. Энэ мөнгийг мацгийн өргөл гэдэг. Сүм мацгийн өргөлийг ядуус хийгээд гачигдалтай хүмүүст туслахад ашигладаг.

Бид мацаг барьж мөн өөрсдийн Бурханыг эрэлхийлэв, **Езра** 8:21–23, 31. Би мацаг барьж мөн тэнгэрийн Бурханы өмнө залбирав, **Нех.** 1:4. Та нар миний төлөө мацаг барь, гурван өдөр юу ч бүү ид, юу ч бүү уу, **Естер** 4:16. Би мацаг барилтаар сэтгэлээ даруусгасан, **Дуул.** 35:13. Энэ чинь миний сонгосон мацаг барилт биш гэж үү? **Иса.** 58:3–12. Би залбирал ба мацаг барилтаар Эзэн Бурханыг хайхаар хичээнгүйлэн хандав, **Дан.** 9:3. Та нар бүх зүрх сэтгэл хийгээд мацаг барилтаар над уруу эргэгтүн, **Иоел** 2:12. Ниневе Бурханд итгэж, мөн мацаг барилт зарлав, **Иона** 3:5. Есүс дөчин өдөр мацаг барив, **Мат.** 4:2 (Ег. 34:28; Хаад.дээд 19:8; Лук 4:1–2). Мацаг барьж байгаагаа хүмүүст бүү харуул, **Мат.** 6:18 (3 Ниф. 13:16). Энэ төрлийн чөтгөр залбирал ба мацаг барилтаар гадагш гардаг, **Мат.** 17:21. Мацаг барилт болон залбиралд үргэлжлүүлэгтүн, **Омн.** 1:26 (4 Ниф. 1:12). Тэд өөрсдийн Их Эзэн

Бурханд мацаг барьж, мөн залбирч эхлэв, **Моз.** 27:22. Би эдгээр зүйлүүдийг мэдэж болохын тулд олон өдөр мацаг барьж мөн залбирав, **Алма** 5:46. Бурханы хүүхдүүд мацаг барилт болон хүчирхэг залбиралд нэгдэв, **Алма** 6:6. Мозаягийн хөвгүүд өөрсдийгөө их залбирал хийгээд мацаг барилтад зориулав, **Алма** 17:3, 9. Олон нифайчуудын үхлийн дараа мацаг барилт хийгээд залбирлын үе ирэв, **Алма** 28:5–6. Тэд ихэд мацаг барьж мөн ихэд залбирав, **Алма** 45:1 (Хил. 3:35). Мацаг барилт чинь төгс байхын тулд хоол хүнс тань нэгэн үзүүрт сэтгэлээр бэлтгэгдэг, **С ба Г** 59:13–14. Та нар залбирал хийгээд мацаг барилтад үргэлжлүүлэх ёстой, **С ба Г** 88:76.

МЕЛКИЗЕДЕК. Мелкизедек санваар; Салемыг *мөн* үз

Үерийн дараа болон Абрахамын үед амьдарч асан, Хуучин Гэрээний агуу дээд санваартан, бошиглогч бөгөөд удирдагч. Тэрбээр Салемын (Иерусалем) хаан, энх амгалангийн хаан, зөв шударгын хаан (Мелкизедекийн еврей хэлний утга), мөн бүхнээс дээд Бурханы санваартан хэмээн нэрлэгддэг байжээ.

Абрахам аравны нэгийг Мелкизедект төлдөг байв, **Эхл.** 14:18–20. Мелкизедекийн хүмүүс зөв шударгыг үйлдэж, мөн тэнгэрийг олсон буюу, **ИСО,** **Эхл.** 14:25–40. Христ Мелкизедекийн жаягийн дагуу дээд санваартан байв, **Евр.** 5:6. Мелкизедек бол Салемын хаан, бүхнээс дээд Бурханы санваартан байжээ, **Евр.** 7:1–3. Хэн ч Мелкизедекээс илүү агуу байсангүй, **Алма** 13:14–19. Абрахам санваарыг Мелкизедекээс хүлээн авчээ, **С ба Г** 84:14. Их Эзэний нэрийг хүндэтгэхийн тулд, эртний Сүм дээд санваарыг Мелкизедек Санваар хэмээн нэрлэдэг байжээ, **С ба Г** 107:1:4.

МЕЛКИЗЕДЕК САНВААР.

Ахлагч; Мелкизедек;

Санваарыг *мөн* үз

Мелкизедек санваар бол дээд буюу

их санваар; Аароны санваар бол бага санваар юм. Мелкизедек санваар нь Сүмийн сүнсний адислалуудын түлхүүрүүдийг өөртөө багтаадаг. Дээд санваарын ёслолуудаар дамжин бурханлиг чанарын хүч хүмүүнд мэдэгдсэн буюу (**С ба Г** 84:18–25; 107:18–21).

Бурхан энэхүү дээд санваарыг анх удаа Адамд илчилжээ. Эрин үе бүхэнд патриархууд хийгээд бошиглогчид энэхүү эрх мэдэлтэй байжээ (**С ба Г** 84:6–17). Энэ нь эхлээд Бурханы Хүүгийн жаягийн дагуу Ариун санваар хэмээн нэрлэгддэг байв. Хожим нь Мелкизедек санваар гэгдэх болсон байна (**С ба Г** 107:2–4).

Израилын хүүхдүүд Мелкизедек санваарын онцгой боломж хийгээд гэрээнүүдийн дагуу амьдрахаа больсон үед, Их Эзэн энэхүү дээд хуулийг татан авч бага санваар хийгээд бага хуулийг тэдэнд өгчээ (**С ба Г** 84:23–26). Эдгээр нь Аароны санваар болон Мосегийн хууль хэмээн нэрлэгддэг байлаа. Есүс дэлхийд ирсэн үедээ Мелкизедек санваарыг иудейчүүдэд сэргээж, тэдний дунд Сүм байгуулж эхэлсэн билээ. Гэсэн ч, урвалтын улмаас санваар хийгээд Сүм алга болсон байлаа. Эдгээр нь хожим Бага Иосеф Смитээр дамжин сэргээгджээ (**С ба Г** 27:12–13; 128:20; **ИС**—**Т** 1:73).

Мелкизедек санваар дотор ахлагч, дээд санваартан, патриарх, дал, түүнчлэн Төлөөлөгчийн албан тушаалууд байдаг (**С ба Г** 107). Мелкизедек санваар нь дэлхий дээрх Бурханы хаант улсын нэг хэсэг ямагт байх болно.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгэнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгч нь дээд буюу Мелкизедек санваартны ерөнхийлөгч бөгөөд, тэрээр дэлхий дээрх Бурханы хаант улсад хамаардаг бүх түлхүүрүүдийг атгадаг. Ерөнхийлөгчийн дуудлага нь тодорхой цаг үед зөвхөн нэг хүнд байх бөгөөд тэр бол санваарын бүх түлхүүрүүдийг хэрэгжүүлэх эрх мэдэл бүхий энэ дэлхий дээрх

цорын ганц хүн мөн (С ба Г 107:64–67; С ба Г 132:7).

Мелкизедекийн жаягийн дагуу Христ үүрд мөнхөд санваартан байх болно, **Дуул.** 110:4 (Евр. 5:6, 10; 7:11). Мелкизедек санваар нь сайн мэдээнд үйлчилдэг, **Евр.** 7 (С ба Г 84:18–25). Мелкизедек хүчирхэг итгэлийг бодитой болгож, мөн дээд санваарын албан тушаалыг хүлээн авсан билээ, **Алма** 13:18. Мелкизедек санваарыг Иосеф Смит Оливер Каудери хоёрт хүртээв, **С ба Г** 27:12–13 (ИС—Т 1:72). Энэхүү санваар тангараг хийгээд гэрээгээр хүлээн авагдав, **С ба Г** 84:33–42. Мелкизедек болон Аароны санваар гэсэн хоёр хэсэг буюу зааг байдаг, **С ба Г** 107:6. Бүх сүнслэг адислалуудыг гүйцэтгэх эрхийг Мелкизедек санваар атгадаг. **С ба Г** 107:8–18. Мосе, Елиас, Елиа нар Иосеф Смит Оливер Каудери хоёрт санваарын түлхүүрүүдийг өгчээ, **С ба Г** 110:11–16. Түлхүүрүүдийг нь та нар атгаж болохын тулд эдүгээ би өөрийнхөө санваарт хамаарах албан тушаалуудыг би та нарт өгч байна, **С ба Г** 124:123.

МЕССИА. Адислагдсан Нэгэн;
Есүс Христийг мөн үз

“Тослогдсон” гэсэн утгатай арамей болон еврей үгийн хэлбэр. Шинэ Гэрээнд Есүс Христ гэж нэрлэгддэг нь грек хэлээр *Мессиа* гэсэнтэй адил юм. Энэ нь ирэхийг нь иудейчүүд нэн ихээр хүсэн хүлээж асан тослогдсон Бошиглогч, Санваартан, Хаан түүнчлэн Чөлөөлөгч гэсэн утгатай юм.

Олон иудейчүүд зөвхөн үндэсний илүү агуу цэцэглэл хөгжилтийн төлөө Ромын эзэгнэлээс чөлөөлөх чөлөөлөгчийг хүсэн хүлээж байлаа; тийнхүү, Мессиаг ирэхэд удирдагчид хийгээд бусад олон хүмүүс түүнийг няцаасан билээ. Гагцхүү даруу хийгээд итгэлтэй хүмүүс Назарын Есүст үнэнхүү Христийг харжээ (Иса. 53; Мат. 16:16; Иохан 4:25–26).

Мессиа Сүнстэй байж, сайн мэдээг номлон, мөн эрх чөлөөг тунхаглах болно, **Иса.** 61:1–3 (Лук 4:18–21). Бид Христ хэмээн хөрвүүлэгддэг Мессиаг оллоо, **Иохан** 1:41 (Иохан 4:25–26). Бурхан иудейчүүдийн дунд Мессиаг, эсвээс өөр үгээр Аврагчийг төрүүлсэн билээ, **1 Ниф.** 10:4. Бурханы Хүү нь тэр ирэх ёстой Мессиа байсан бөлгөө, **1 Ниф.** 10:17. Гэтэлгэл нь ариун Мессиад мөн түүгээр дамжин ирдэг буюу, **2 Ниф.** 2:6. Мессиа цаг хугацааны бүрэн вайдлын үед ирэх болно, **2 Ниф.** 2:26. Мессиа нас барагсдаас босч ирэх болно, **2 Ниф.** 25:14. Мессиагийн нэрээр би Аароны санваарыг хүртээж байна, **С ба Г** 13:1. Би Мессиа, Сионы Хаан байна хэмээн Их Эзэн өгүүлэв, **Моце** 7:53.

МЕТУСЕЛА. Енохыг мөн үз

Хуучин Гэрээн дэх Енохын хүү. Метусела 969 жил амьдарчээ (Эхл. 5:21–27; Лук 3:37; Моце 8:7). Тэрээр Енохын хот тэнгэрт аваачигдахад дэлхий дээр үлдсэн зөв шударга бошиглогч юм. Ноагаар дамжин ирэх ёстой байсан цэцэглэл хөгжилтийг хангахын тулд тэрээр дэлхий дээр үлдсэн ажээ (Моце 8:3–4).

МЕШАХ. Даниелыг мөн үз

Хуучин Гэрээнд, Шадрах, Мешах, Абед-него нар бол Вавилоны хаан Небухаднезарын ордонд аваачигдсан, гурван залуу израил хүн юм. Мешахын еврей нэр нь Михаил байв. Дөрвөн залуу эр хааны зоог хийгээд дарснаас хүртэж өөрсдийгөө бузарлахаас татгалзжээ (Дан. 1). Шадрах, Мешах, Абед-него гурвыг хаан зууханд хаясан хэдий ч, Бурханы Хүү авран хамгаалжээ (Дан. 3).

МИКА

Хуучин Гэрээний бошиглогч. Тэрбээр Иудейн тал нутгийн Морешет Гатын уугуул нутгийн хүн байсан бөгөөд Хезекиаг хаан байх үед бошиглож байжээ (Мика 1:1–2).

Микагийн ном: Бетлехем бол Мессиагийн төрөх тэрхүү газар мөн хэмээн нэрлэсэн Хуучин Гэрээн дэх цорын ганц ном бол Мика юм (Мика 5:2). Энэ номонд Их Эзэн өөрийн хүмүүст зөвлөгөө өгч мөн өнгөрсөн үе дэх өөрийн нинжин сэтгэлийг тэдэнд дахин харуулжээ; тэрбээр тэднээс шударга ёс, нигүүлсэл хийгээд даруу байдлыг шаардсан ажээ (Мика 6:8).

МИРИАМ. Мосег *мөн үз*

Хуучин Гэрээнд, Мосегийн эгч (Тоол. 26:59).

Зэгсээр хийсэн сагсыг харж байв, **Ег.** 2:1–8. Хэнгэрэг авч эмэгтэйчүүдийг дагуулав, **Ег.** 15:20–21. Мосегийн эсрэг үглэж мөн уяман өвчтэй болж, тэгээд эдгээгдэв, **Тоол.** 12:1–15 (Дэд хууль. 24:9).

МИССУРИ. Шинэ Иерусалемыг үз

МИХАИЛ. Адам; Тэргүүн тэнгэр элчийг *мөн үз*

Мөнх бус амьдралын өмнөх үед байсан Адамын нэр. Тэрбээр Тэргүүн тэнгэр элч хэмээн нэрлэгддэг байв. Еврей хэлэнд энэ нэр нь хэн “Бурхантай адилхан бэ” гэсэн утгатай.

Тэргүүн жононгуудын нэг Михаил надад туслахаар ирсэн, **Дан.** 10:13, 21 (С ба Г 78:16). Хожмын үед агуу жонон Михаил босно, **Дан.** 12:1. Тэргүүн тэнгэр элч Михаил диаволтай сөргөлдөв, **Иуда** 1:9. Михаил болон түүний тэнгэр элч нар луутай тулалдлаа, **Илч.** 12:7 (Дан. 7). Михаил бол Адам мөн, **С ба Г** 27:11 (С ба Г 107:53–57; 128:21). Их Эзэний тэргүүн тэнгэр элч, Михаил бүрээгээ үлээх болно, **С ба Г** 29:26. Михаил их цэргээ цуглуулж мөн Сатантай тулалдах болно, **С ба Г** 88:112–115. Чөтгөрийг ялгасан Михаилын дуу хоолой сонсогдов, **С ба Г** 128:20.

МОАБ. Лотыг *мөн үз*

Хуучин Гэрээний үе дэх Сөнөсөн Тэнгисийн зүүнтэй орших газар.

Моабчууд бол Лотын удмынхан бөгөөд израилчуудад хамаардаг байжээ. Тэд еврей хэлтэй адил хэлээр ярьдаг байв. Моабчууд хийгээд израилчууд хоорондоо байнга дайлдаг байжээ (Шүүгч. 3:12–30; 11:17; 2 Сам. 8:2; Хаад. дэд 3:6–27; Шаст. дэд. 20:1–25; Иса. 15).

МОЗАЯ, БЕНЖАМИНЫ ХҮҮ.

Бенжамин, Мозаягийн эцэг;
Мозая, Түүний хөвгүүдийг
мөн үз

Мормоны Номон дахь нифайчуудын зөв шударга хаан болон бошиглогч. Мозая эцгийнхээ зөв шударга үлгэр жишээг дагадаг байв (Моз. 6:4–7). Тэрээр жаредчуудын цэдгийг агуулсан хорин дөрвөн алтан ялтсыг орчуулжээ (Моз. 28:17).

Мозаягийн ном: Мормоны Номон доторх нэг ном. Бүлэг 1–6 нь өөрийн хүмүүст хийсэн хаан Бенжамин албадлагын номлолыг агуулдаг. Их Эзэний Сүнс тэдний зүрх сэтгэлд хүрч мөн хүмүүс хөрвүүлэгдэн, цаашид хилэнц үйлдэх хүсэлгүй болжээ. Бүлэг 7–8 нь леменчүүдтэй хамт амьдрахаар одсон хэсэг нифайчуудын тухай өгүүлдэг. Тэднийг эрж олохоор эрлийн бүлгийг араас нь явуулжээ. Эрлийн бүлгийн удирдагч Аммон тэднийг олж, тэд леменчүүдийн дарлал дор зовж зүдэрч байгаа тухай сонсчээ. Бүлэг 9–24 нь тэрхүү дарлал хийгээд леменчүүдийн эрхэнд байсан тэдний удирдагчид—Зениф, Ноа болон Лимхай нарыг дүрслэн харуулсан байдаг. Абинадай хэмээн нэрлэгддэг асан нэг бошиглогч алагдсан тухай мөн тэмдэглэгдсэн байдаг. Алма Абинадайн сорилтод хөрвүүлэгдсэн байлаа. Бүлэг 25–28 нь Алмагийн хүү болон Хаан Мозаягийн дөрвөн хөвгүүн хэрхэн хөрвүүлэгдсэн тухай түүхүүдийг хүүрнэдэг. Бүлэг 29-д Хаан Мозая, хаадыг орлох шүүгчдийн тогтолцоог санал болгосон байдаг. Алмагийн хүү Алма анхны ерөнхий шүүгчээр сонгогджээ.

МОЗАЯ, БЕНЖАМИНЫ ЭЦЭГ.

Бенжамин, Мозаягийн эцэг;
Зарахемлаг *мөн үз*

Мормоны Номонд, Зарахемла дахь хүмүүсийн хаан болгогдсон нифайчуудын бошиглогч.

Нифайн нутгаас зугтан гарахаар Мозая сэрэмжлүүлэгдсэн байлаа, **Омнаи** 1:12. Тэрээр Зарахемлагийн хүмүүсийг олж мэдэв, **Омнаи** 1:14–15. Зарахемлагийн хүмүүс түүнд өөрийнх нь хэлээр ааж байв, **Омнаи** 1:8. Тэрээр нэгдсэн хүмүүсийн хаан байхаар томилогджээ, **Омнаи** 1:19. Түүнийг үхсэний дараа түүний хүү Бенжамин засаглав, **Омнаи** 1:23.

МОЗАЯ, ТҮҮНИЙ ХӨВГҮҮД.

Аарон, Мозаягийн хүү; Аммон, Мозаягийн хүү; Мозая, Бенжамины хүү; Омнер; Химнайг *мөн үз*

Мормоны Номонд Хаан Мозаягийн дөрвөн хөвгүүн тэдэн дээр тэнгэр элч хүрч ирэн, мөн тэднийг наманчлалд дуудсаны дараа хөрвүүлэгджээ. Тэдний нэр нь Аммон, Аарон, Омнер, Химнай байв (Моз. 27:34). Тэд сайн мэдээг леменчүүдэд арван дөрвөн жилийн турш амжилттай номлов. Леменчүүдийн дундах тэдний тохинууллын цэдэг Алмагийн номны бүлэг 17–26-д байдаг.

Эхлээд тэд Сүмийг устгахыг оролдож байсан үл итгэгчид байв, **Моз.** 27:8–10 (Алма 36:6). Тэд тэнгэр элчээр шүүмжлэгдэж, тэгээд наманчлав, **Моз.** 27:11–12, 18–20. Тэд леменчүүдэд номлох зөвшөөрлийг олов, **Моз.** 28:1–7.

МОРМОН, НИФАЙЧУУДЫН БОШИГЛОГЧ. Мормоны

Номыг *мөн үз*

Нифайчуудын бошиглогч, цэргийн жанжин, түүнчлэн Мормоны Номон дахь цэдэг хөтлөгч. Мормон мэ 311–385 оны үед амьдарч байжээ. (Морм. 1:2; 6: 6:5–6; 8:2–3). Тэрээр арван таван настайгаасаа эхлэн

амьдралынхаа ихэнх хугацаанд цэргийн дарга байжээ (Морм. 2:1–2; 3:8–12; 5:1; 8:2–3). Цэдгүүдийг хариуцах хийгээд цэдэг хөтлөхөд өөрийгөө бэлтгэхийг Аммарон Мормонд зааварлажээ (Морм. 1:2–5; 2:17–18). Хувийнхаа амьдралын түүхийн цэдгээр Мормон, Нифайн том ялтсуудыг Мормоны ялтсууд дээр хураангуйлан тэмдэглэжээ. Хожим нь тэрээр энэхүү ариун цэдгийг хүү Моронайдаа шилжүүлж өгсөн байна. Эдгээр ялтсууд бол Мормоны Номыг Иосеф Смит орчуулсан цэдгийн нэг хэсэг байлаа.

Мормоны Үгс: Мормоны Номон дахь нэг жижигхэн ном. Омнаин номон дахь Амаликайн сүүлчийн үгс болон Мозаягийн номон дахь эхний үгсийн хоорондох бүх цэдгүүдийн хянан тохиолдуулагч Мормон, энэ бяцхан оруулгыг хийжээ. (Мормоны Номны өмнөх “Мормоны Номны тухай товч тайлбар”-ыг үз.)

Мормоны Ном: Мормоны Ном хэмээн нэрлэгддэг боть судрын доторх тусдаа нэг ном. Бүлэг 1–2-т ялтсуудыг хэзээ, хаанаас авахыг Мормонд зааварлаж буй нифайчуудын бошиглогч Аммароны тухай өгүүлдэг. Түүнчлэн, их дайнууд эхэлж, мөн хүмүүсийн ёс бусаас болж, гурван нифай хүнийг авч явсан байлаа. Бүлэг 3–4-т хүмүүст наманчлалыг гуйн тунхаглаж буй Мормоны тухай өгүүлдэг: гэвч тэд мэдрэмжээ алдаж, түүнчлэн урьд өмнө Израилд хэзээ ч байгаагүй ёс бус явдал газар авчээ. Бүлэг 5–6 нь нифайчууд хийгээд леменчүүдийн хоорондох сүүлчийн тулалдаануудын тухай өгүүлдэг. Мормон нифай үндэстний олонхтой хамт алагдсан байв. Бүлэг 7-д, Мормон үхэхийнхээ өмнө—тэр үед болон ирээдүйд—наманчлахыг хүмүүст уриалжээ. Бүлэг 8–9-д, эцэстээ ганцхан Мормоны хүү Моронай үлдсэнийг тэмдэглэжээ. Тэрээр Нифайн хүмүүсийн төгсгөлийг оролцуулан, үхэл хийгээд хүйс тэмтрэлтийн эцсийн зураглалыг

цэдэглэн, ирээдүй үеийнхэн хийгээд энэ цэдгийн уншигчдад хандсан захиас бичжээ.

МОРМОН (ЧУУД). Есүс Христийн Сүм, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг *мөн үз*

Мормон хэмээх нэрийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийг нэрлэхийн тулд Сүмийн гишүүн биш хүмүүс зохиожээ. Уг нэр нь эрт үеийн бошиглогч Мормоны зохиосон судрын ариун номноос гаралтай бөгөөд Мормоны Ном үүгээр нэрлэгдсэн юм. Сүмийн гишүүдэд Их Эзэнээр өгөгдсөн нэр нь “Гэгээнтнүүд” юм. Сүмийн зөв нэр нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм юм.

МОРМОНЫ НОМ. Алтан

Ялтсууд; Бага Иосеф Смит;
Ефраим — Ефраимын болон
Иосефын Саваа; Канон;
Мормон, Мормоны Номны
гэрчүүд; Нифайчуудын
Бошиглогч; Судрууд;
Ялтсуудыг *мөн үз*

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хүлээн зөвшөөрөгдсөн дөрвөн боть судрын нэг. Энэ бол эртний бошиглогч Мормоны хураангуйлсан Америкийн эртний оршин суугчдын цэдэг юм.

Энэ нь Есүс бол Христ гэдгийг гэрчлэхээр бичигджээ. Энэхүү цэдгийн тухай Бурханы бэлэг болон хүчний дагуу орчуулсан Бошиглогч Иосеф Смит, “Би ах нарт хэлсэнчлэн Мормоны Ном бол энэ дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв нь, мөн шашны маань тулгуурын чулуу, мөн бусад ямар ч номноос илүүгээр үүний зааврыг мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох болой” хэмээжээ (Мормоны Номын өмнөх удиртгалыг үз).

Мормоны Ном бол Америк тивд Хуучин дэлхийгээс шилжин

суурышсан гурван бүлэг хүмүүсийн шашны цэдэг юм. Эдгээр бүлгүүд нь өөрсдийн шашны болон бусад түүхийг метал ялтсууд дээр цэдэглэсэн бошиглогчдоор удирдуулсан байжээ. Амилсныхаа дараахан Америк тивийн хүмүүст зочилсон Есүс Христийн айлчлалтыг Мормоны Ном цэдэглэжээ. Христийн тэр айлчлалтын дараа хоёр зуун жилийн энх амгалан дагалдсан байна. Нифайчуудын сүүлчийн бошиглогч, түүхч Моронай эдгээр хүмүүсийн хураангуйлсан цэдгийг лацдаж мөн мэ 421 онд нуужээ. Амилуулагдсан Моронай 1823 онд Иосеф Смитэд зочилж, мөн хожим нь энэхүү эртний ариун нандин цэдгийг орчуулж, мөн Есүс Христийн бас нэгэн гэрч болгон дэлхийд урагш авчрахаар түүнд өгчээ.

Иосеф нь үр жимс ихтэй мөчир нь ханыг даван ургах саглагар мөчир, **Эхл.** 49:22–26. Үнэн газраас оргилон гардаг, **Дуул.** 85:11 (Морм 8:16; Мосе 7:62). Их Эзэн үндэстнүүд уруу туг өргөж, мөн тэдэн уруу исгэрнэ, **Иса.** 5:26. Дуу хоолой шороон дотроос ярих болно, **Иса.** 29:4 (2 Ниф. 26:14–17). Бүх үзэгдэл лацдуулсан номын үгс мэт болно, **Иса.** 29:11 (Иса. 29:9–18; 2 Ниф. 27:6–26). Иосефын мөн Иудагийн саваанууд Их Эзэний мутарт нэг байх болно, **Эзек.** 37:15–20. Энэ хашаан дахь сүргээс өөр сүрэг надад бий, **Иохан** 10:16 (3 Ниф. 15:16–24). Мормоны Ном Библи хоёр хамтдаа өсч ондийнө, **2 Ниф.** 3:12–21. Их Эзэний үгс дэлхийн төгсгөл хүртэл урагш исгэрэх болно, **2 Ниф.** 29:2. Их Эзэн Мормоны Номыг леменчүүдэд урагш авчрахаар Иностой гэрээнд оров, **Инос** 1:15–16. Мормоны Ном биднийг Библид итгүүлэх зорилгоор бичигджээ, **Морм.** 7:9. Мормоны Ном Дэлхийнхний эсрэг гэрчлэл болон зогсоно, **Ифер** 5:4. Эдгээр зүйлүүд үнэн эсэхийг Бурханаас асуу, **Моро.** 10:4. Мормоны Ном үнэн болохыг Христ гэрчилсэн болой, **С ба Г** 17:6. Мормоны Ном Есүс

Христийн бүрэн сайн мэдээг агуулдаг, **С ба Г 20:9** (С ба Г 20:8–12; 42:12). Мормоны Ном Бурханы үг гэдэгт бид итгэдэг, **ИТ 1:8**.

МОРМОНЫ НОМНЫ ГЭРЧҮҮД.

Гэрч; Мормоны Номыг *мөн үз*

Мормоны Номын бурханлиг чанарыг гэрчлэхийг Бошиглогч Иосеф Смитээс өөр хүмүүст Их Эзэн зарлиглажээ (С ба Г 17; 128:20). Мормоны Номын өмнөх Удиртгал дахь эдгээр гэрчлэгчдийн гэрчлэлүүдийг үз.

Гурвын үгсээр би өөрийнхөө үгийг тогтоох болно, **2 Ниф.** 11:3. Гэрч нар хүмүүний үрст түүний үгийг гэрчилдэг, **2 Ниф.** 27:12–13. Гурван гэрчийн амаар эдгээр зүйлүүд тогтоогдох болно, **Ифер** 5:4. Гурван Гэрч итгэлээр ялтсуудыг үзэх болно, **С ба Г 17**.

МОРОНАЙ, АХМАД. Эрх чөлөөний тугийг *мөн үз*

Мормоны Номонд, мээ 100 оны үед амьдарч асан, нифайчуудын зөв шударга, цэргийн захирагч.

Моронай нифайчуудын бүх цэргийн ерөнхий ахмадаар томилогдов, **Алма** 43:16–17. Нифайн цэргүүдийг эрх чөлөөнийхөө төлөө тулалдахад зоригжуулж байв, **Алма** 43:48–50. Нөмрөгнийхөө уранхайгаар эрх чөлөөний туг хийв, **Алма** 46:12–13. Бурханы хүн байв, **Алма** 48:11–18. Засгийн газарт уурлаж байв, улс орныхоо эрх чөлөөний талаарх тэдний хайхрамжгүйн учир бөлгөө, **Алма** 59:13.

МОРОНАЙ, МОРМОНЫ ХҮҮ.

Мормоны Ном; Нифайчуудын бошиглогч Мормоныг *мөн үз*

Мормоны Номон дахь нифайчуудын сүүлчийн бошиглогч (мэ 421 оны орчимд). Мормоныг үхэхийн дөнгөж өмнөхөн, тэрээр Мормоны ялтсууд хэмээн нэрлэгддэг байсан түүхэн цэдгийг хүү Моронайдаа дамжуулан өгчээ (Морм.үгс. 1:1).

Мормоны ялтсуудын эмхтгэлийг Моронай дуусгажээ. Тэрээр Мормоны Номонд бүлэг 8 болон 9-ийг нэмж оруулсан байна (Морм. 8:1). Тэрээр Иферийн номыг хураангуйлан оруулж, мөн Моронайн ном хэмээн нэрлэгдсэн өөрийн номыг нэмж оруулжээ (Моро. 1:1–4). Моронай ялтсуудыг лацдаж мөн тэдгээрийг Кумора гүвээнд нуужээ (Морм. 8:14; Моро. 10:2). 1823 онд Моронай Иосеф Смитэд Мормоны Номыг илчлэхийн тулд амилуулагдсан дүрээр илгээгдсэн байв (ИС—Т 1:30–42, 45; С ба Г 27:5). Тэрээр 1823–1827 оныг хүртэл залуу бошиглогчийг жил бүр зааварлаж (ИС—Т 1:54) мөн эцэст нь 1827 онд ялтсуудыг түүнд шилжүүлж өгчээ (ИС—Т 1:59). Орчуулга дууссаны дараа Иосеф Смит ялтсуудыг Моронайд буцааж өгсөн байна.

Моронайн Ном: Мормоны Номон дахь сүүлчийн ном. Уг номыг нифайчуудын сүүлчийн бошиглогч Моронай бичжээ. Бүлэг 1–3 нь Ариун Сүнс хийгээд санваарыг хүртээх талаар заавар өгч, нифайчуудын бүрэн устгалын тухай өгүүлдэг. Бүлэг 4–5 нь ариун ёслолыг гүйцэтгэх хэлбэр маягийг нарийн тодорхой харуулдаг. Бүлэг 6-д Сүмийн ажлыг нэгтгэн дүгнэсэн байдаг. Бүлэг 7–8 нь сайн мэдээний анхдагч зарчмуудын талаарх үйлчлэлүүд, түүний дотор итгэл, найдвар мөн энэрэл болон сайн ба мууг шүүх арга замын талаарх Мормоны сургаалууд (Моро. 7), түүнчлэн бяцхан хүүхдүүд Христэд амьд бөгөөд баптисм шаардлагагүй хэмээх Мормоны тайлбар юм (Моро. 8). Бүлэг 9 нь нифай үндэстний эвлрэлийг дүрслэн харуулжээ. Бүлэг 10 нь Моронайн сүүлчийн захиас бөгөөд Мормоны Ном үнэнийг мэдэх арга замыг багтаажээ (Моро. 10:3–5).

МОРОНАЙХА, АХМАД МОРОНАЙН ХҮҮ

Мормоны Номон дахь нифайчуудын зөв шударга цэргийн захирагч (мээ 60 оны орчим).

Моронай их цэргийнхээ удирдлагыг өөрийн хүү Моронайхагийн гарт өгөв, **Алма** 62:43. Зарахемла хотыг буцаан авав, **Хил.** 1:33. Леменчүүдийг наманчлалд авчирч, нутагтаа тавих хяналтыг дахин олж авав, **Хил.** 4:14–20.

МОСЕ. Аарон, Арван зарлиг, Мосегийн Хууль; Мосегийн ах; Пентатеух; Хувиралт—Христийн хувиралтыг мөн үз

Израилчуудыг Египетийн боолчлолоос удирдан гаргаж, Бурханаар илчлэгдсэний дагуу шашин, нийгмийн болон хооллох хуулиудыг тэдэнд өгсөн Хуучин Гэрээний бошиглогч.

Мосегийн тохинуулал нь түүний мөнх бус амьдралын хязгаараас давж гарсан юм. Тэрээр Елиагийн хамт Хувиралтын Ууланд ирж, Петр, Иаков болон Иоханд санваарын түлхүүрүүдийг өгснийг Иосеф Смит заасан байдаг (**Мат.** 17:3–4; **Марк** 9:4–9; **Лук** 9:30; **С ба Г** 63:21).

1836 оны дөрөвдүгээр сарын 3-нд Мосе, Огайогийн Көртландад Иосеф Смит Оливер Каудери хоёр дээр хүрч ирэн, Израилыг цуглуулах түлхүүрүүдийг тэдэнд олгожээ (**С ба Г** 110:11).

Хожмын үеийн илчлэлтэд Мосегийн талаар ихийг өгүүлдэг. Тэрбээр Мормонд Номонд олонтаа дурдагддаг, түүнчлэн Сургаал ба Гэрээнээс бид түүний тохинууллын (**С ба Г** 84:20–26) тухай мөн тэрээр санваарыг хадам эцэг Иетрогоос хүлээн авсныг (**С ба Г** 84:6) мэддэг билээ.

Хожмын үеийн илчлэлт нь түүнчлэн Израилын хүүхдүүдийн дундах түүний тохинууллын талаарх библийн шастирыг нотолж, мөн тэр бол Хуучин Гэрээг эхэлдэг эхний таван номын зохиогч болохыг дахин нотолж байгаа болно (**1 Ниф.** 5:11; **Моце** 1:40–41).

Фараоны охиноор аврагдав, **Ег.** 2:1–10. Мидиан уруу зугтав, **Ег.** 2:11–22. Эзэний тэнгэр элч шагаж буй бутан дотор түүнд үзэгдэв, **Ег.** 3:1–15.

Египетчүүд дээр ирэх өвчин тахлуудыг мэдэгдэв, **Ег.** 7–11. Дээгүүр өнгөрсний баярыг Их Эзэн бий болгов, **Ег.** 12:1–30. Израилын хүүхдүүдийг Улаан Тэнгисээр гаталган удирдав, **Ег.** 14:5–31. Их Эзэн цөлд мангаж илгээв, **Ег.** 16. Хоробын хадыг цохиж, тэндээс ус гарав, **Ег.** 17:1–7. Иошуа Амалекийн эсрэг давамгайлахын тулд Аарон, Хур нар түүний гарыг түшив, **Ег.** 17:8–16. Иетро түүнд зөвлөв, **Ег.** 18:13–26. Синайн Уулан дээр Их Эзэнийг хүрч ирэхэд хүмүүсийг бэлтгэв, **Ег.** 19. Их Эзэн Арван Хуулийг түүнд илчлэв, **Ег.** 20:1–17. Тэр болон далан ахлагч Бурханыг харав, **Ег.** 24:9–11. Хавтангуудыг эвдэж, алтан тугалыг устгав, **Ег.** 32:19–20. ЭЗЭН Мосетой нүүр нүүрээрээ тулан ярьдаг байлаа, **Ег.** 33:9–11. Есүсийг хувирч өөрчлөгдөхөд хүрч ирэв, **Мат.** 17:1–13 (**Марк** 9:2–13; **Лук** 9:28–36). Мосегийн адил хүчтэй байцгаая, **1 Ниф.** 4:2. Христ бол Их Эзэний төрүүлсэн Мосегийн адил бошиглогч билээ, **1 Ниф.** 22:20–21 (**3 Ниф.** 20:23; **Дэд хууль** 18:15). Израилыг илчлэлтээр удирдав, **С ба Г** 8:3. Сурвалжит боггалиудын дунд харагдав, **С ба Г** 138:41. Бурханыг нүүр тулан харав, **Моце** 1:2, 31. Төрсөн Ганцтай адил төстэй байв, **Моце** 1:6, 13. Бүтээлтийн талаар түүнд илэрхийлэгдсэн зүйлүүдийг бичихээр завдаж байв, **Моце** 2:1.

Мосегийн ном: Эхлэлийн эхний долоон бүлгийг Иосеф Смитийн сүнсээр удирдагдсан орчуулгыг агуулсан Агуу Үнэт Сувд дахь нэг ном.

Бүлэг 1 нь авралын бүхэл төвлөлөгөөг өөрт нь илчилсэн Бурханыг Мосе харсан тэрхүү үзэгдлийн тухай өгүүлдэг. Бүлэг 2–5 нь Бүтээлтийн хийгээд хүмүүний уналтын шастир юм. Бүлэг 6–7 нь Енос болон дэлхий дээрх тохинууллын тухай үзэгдлийг агуулдаг. Бүлэг 8 нь Ноа болон агуу их үерийн тухай үзэгдлийг агуулдаг.

Мосегийн таван ном: Эхлэл; Египетээс Гарсан нь; Левит; Тооллого; Дэд Хуулийг үз

Хуучин Гэрээний эхний таван номыг Мосегийн номнууд гэдэг. Мосегийн номнуудыг агуулсан зэс ялтсуудыг Нифай Лебенээс авчээ (1 Ниф. 5:11).

Мосегийн номонд бичигдсэн олон зүйлийг Нифай уншжээ, **1 Ниф.** 19:23.

МОСЕГИЙН ХУУЛЬ. Аароны санваар; Мосе; Хууль; Цэвэр ба Цэвэр бусыг *мөн үз*

Тэд дуулгавартай дагаж чадаагүй илүү өндөр түвшний хуулийг орлуулахаар Бурхан Мосегоор дамжуулан хуулиудыг өгчээ (Ег. 34; ИСО, Ег. 34:1–2; ИСО, Дэд хууль 10:2). Хүмүүст үүрэг, хариуцлагуудыг нь сануулахын тулд Мосегийн хууль олон зарчим, дүрэм, ёслол, зан үйл түүнчлэн бэлэгдлүүдээс бүрддэг байв. Уг хууль нь ёс суртахууны хууль, ёс зүй, шашны хийгээд аж амьдралын хуулиуд, гүйцэтгэлүүд, түүний дотор Бурханы тухай, түүнчлэн түүний талаар хүлээх үүргүүдийг нь (Моз. 13:30) тэдэнд сануулах учиртай золиослоуудыг (Лев. 1–7) багтаадаг байв. Итгэл, наманчлал, усанд үйлдэх баптисм, түүнчлэн нүглүүдээс ангижрах нь Арван Зарлиг болон өндөр ёс зүй хийгээд ёс суртахууны үнэ цэнэ бүхий бусад олон зарлигуудын нэгэн адил, уг хуулийн хэсгүүд байлаа. Ёслолын хуулийн ихэнх нь цус урсгасан золиослолоор төгссөн Есүс Христийн үхэл хийгээд амилуулалтаар гүйцэлдсэн байлаа (Алма 34:13–14). Уг хууль Аароны санваарын удирдлага дор гүйцэтгэгдэж байсан бөгөөд өөрийн дагалдагчдыг Христэд авчрах бэлтгэл сайн мэдээ байв.

Би тэдэнд эхнийхийн адил хуулийг өгөх болно, гэвч энэ нь ердийн зарлигийн дагуу байх болно, **ИСО**, Ег. 34:1–2. Уг хууль нь биднийг Христэд аваачихад багш байлаа, **Гал.** 3:19–24. Бид Мосегийн хуулийг сахьж мөн Христэд гуйвшгүй байхыг ширтэн хүлээдэг, **2 Ниф.** 25:24–30. Аврал зөв-

хөн Мосегийн хуулиар ирдэггүй, **Моз.** 12:27–13:32. Мосегийн хууль надаар гүйцэлдсэн бөлгөө, **3 Ниф.** 9:17. Мосед өгөгдсөн хууль надад төгсгөл болсон билээ, **3 Ниф.** 15:1–10. Дуулгаваргүй байдлынх нь улмаас Израилын хүүхдүүдээс Мосе болон Ариун санваарыг Их Эзэн авч, ердийн зарлигуудын хуулийг үлдээсэн билээ, **С ба Г** 84:23–27.

МӨНГӨ. Аравны нэг, Аравны нэгийг төлөх; Баялаг; Дэлхийн шинж чанар; Өглөг, Өглөг өгөхийг *мөн үз*

Зоос, цаасан мөнгө, төлбөрийн картууд эсвээс бараа, үйлчилгээний төлөө төлбөр хийхэд хүмүүс ашигладаг зүйл. Мөнгө нь зарим үед эд материаллаг зүйлийн бэлэг тэмдэг болдог.

Чамайг мөнгөгүйгээр аварна, **Иса.** 52:3. Замдаа юу ч, хэтэвч ч, талх ч, мөнгө ч авч явах ёсгүйг Арванхоёрт хэлжээ, **Марк** 6:8. Мөнгө чинь чамтай хамт мөхөх болно хэмээн Петр илбэ шид үзүүлэгч Симеонд хэлэв, **Үйлс** 8:20. Мөнгөний хайр бол бүх төрлийн бузар муугийн үндэс мөн, **1 Тим.** 6:10. Үнэт биш зүйлд мөнгө бүү үр, **2 Ниф.** 9:50–51 (Иса. 55:1–2; 2 Ниф. 26:25–27). Хэрэв тэд мөнгөний тул хөдөлмөрлөх аваас, тэд эрсдэх болно, **2 Ниф.** 26:31. Та нар баялгуудыг эрэлхийлэхийн өмнө, Бурханы хаант улсыг эрэлхийлэгтүн, **Иаков** 2:18–19. Мөнгөнийхөө учир та нүглээсээ өршөөгдөх болно хэмээн хэлэх сүмүүд байгуулагдах тэр өдөр ирэх болно, **Морм.** 8:32, 37. Сионы зорилгын тулд мөнгө өгдөг тэрээр шагналаа алдах учиргүй, **С ба Г** 84:89–90.

МӨНХ АМЬДРАЛ. Амьдрал; Өргөмжлөл; Селестиел алдар суу; Титэм; Цагаатгал, Цагаатгахыг *мөн үз*

Бурханы дэргэд гэр бүлээрээ үүрд мөнхөд амьдрах (С ба Г 132:19–20, 24, 55). Мөнх амьдрал бол хүмүүнд өгсөн Бурханы хамгийн агуу бэлэг мөн.

Мөнх амийн үгс танд байна, **Иохан** 6:68. Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн, **Иохан** 17:3 (С ба Г 132:24). Итгэлийн сайн тэмцлээр тэмц, мөнх амьдралыг барьж ав, **1 Тим.** 6:12. Эрх чөлөө болон мөнх амьдралыг сонгоход хүмүүс чөлөөтэй бөлгөө, **2 Ниф.** 2:27 (Хил. 14:31). Сүнсээ бодсон байх нь мөнхийн амьдрал юм, **2 Ниф.** 9:39. Тэгвэл та нар мөнх амьдрал уруу хөтлөгч нарийн зам дээр байна, **2 Ниф.** 31:17–20. Христэд итгэж мөн мөн эцсээ хүртэл тэвчих нь мөнх амьдрал билээ, **2 Ниф.** 33:4 (3 Ниф. 15:9). Мөнх амьдралыг авагч тэр нь баян бөлгөө, **С ба Г** 6:7 (С ба Г 11:7). Мөнх амьдрал бол Бурханы бүх бэлгүүдээс хамгийн агуу нь билээ, **С ба Г** 14:7 (Ром 6:23). Зөв шударгыг үйлдэгсэд энэ дэлхийд амар аргаланг, мөн ирэх дэлхийд мөнх амьдралыг хүлээн авах болно, **С ба Г** 59:23. Эцсээ хүртэл тэвчдэг тэд мөнх амьдралын титмийг хүртэх болно, **С ба Г** 66:12 (С ба Г 75:5). Сайн мэдээгүйгээр нас барсан бүгд үүнийг хүлээн авч болох тэд, амьдарч ирсэн тэд селчтиел хаант улсыг өвлөгчид болой, **С ба Г** 137:7–9. Бурханы ажил хийгээд алдар суу нь хүмүүний үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрах явдал мөн, **Моце** 1:39. Бурхан Мөнх амьдралыг дуулгавартнуудад өгдөг, **Моце** 5:11.

МӨНХ БУС, МӨНХ БУС

БАЙДАЛ. Адам Ева хоёрын Уналт; Бие; Бие махбодийн үхэл; Дэлхийг мөн үз

Төрөхөөс эхлээд бие махбодийн үхэл хүртлэх хугацаа. Үүнийг зарим үед хоёр дахь байдал гэж нэрлэдэг.

Чи үүнээс идсэн өдөртөө л зайлшгүй үхнэ, **Эхл.** 2:16–17. (**Моце** 3:16–17). Үхлийн дараа тоос нь урьд байсан газар шороондоо буцаж, сүнс нь түүнийг өгсөн Бурхандаа буцаж ажгуу. **Номл.үгс.** 12:7. Үхлийн биед чинь нүгэл бүү ноёрхог, **Ром.** 6:12. Энэ үхлийн бие нь үхэшгүйг өмсөх

ёстой, **1 Кор.** 15:53 (Инос 1:27; Моз. 16:10; Морм. 6:21). Хүмүүний байдал нь сорилтын байдал болжээ, **2 Ниф.** 2:21 (Алма 12:24; 42:10). Адам хүмүүн байж болохын тул унасан, **2 Ниф.** 2:25. Энэ зуурдын бие үхэшгүй байдалд босгогдохыг та нар урьдаас хардаг уу?, **Алма** 5:15. Энэ амьдрал бол хүмүүн Бурхантай уулзахаар бэлтгэх цаг, **Алма** 34:32. Үхлээс бүү эмээ, учир нь энэ дэлхийд та нарын баясал бүрэн биш болой, **С ба Г** 101:36. Хоёр дахь байдлаа хадгалдаг тэд алдар сууг олох болно, **Абр.** 3:26.

МӨНХ БУС БАЙДЛЫН ӨМНӨХ

АМЬДРАЛ. Тэнгэр дэх дайн; Тэнгэр дэх зөвлөгөөн; Хүмүүс, Хүн; Эхлэлийг мөн үз

Дэлхийн амьдралын өмнөх амьдрал. Эрэгтэй эмэгтэй бүх хүмүүс дэлхийд мөнх бус биетэйгээр ирэхээсээ өмнө Бурхантай хамт түүний сүнсэн хүүхдүүд адил амьдарч байжээ. Үүнийг заримдаа эхний байдал гэж нэрлэдэг (**Абр.** 3:26).

Бурхан дэлхийн суурийг тавихад Бурханы бүх хүүхдүүд баярлан хашгирч байв, **Иов** 38:4–7. Сүнс нь үүнийг өгсөн Бурханд буцаж очдог, **Номл. үгс** 12:7. Чамайг хэвлийд бүрэлдэхээс өмнө би чамайг мэдсэн, **Иер.** 1:4–5. Бид бүгдээрээ түүний үр удам, **Үйлс** 17:28. Дэлхийн сууринаас өмнө Бурхан биднийг сонгосон билээ, **Еф.** 1:3–4. Сүнснүүдийн Эцэгт бид захирагддаг, **Евр.** 12:9. Эхний түвшинг сахиагүй тэнгэр элчүүдийг тэрээр үүрдийн гинжтэй нь хадгалжээ, **Иуда** 1:6 (**Абр.** 3:26). Чөтгөр болон түүний элчүүд хаягдсан, **Илч.** 12:9. Тэд дуудагдаж, мөн дэлхийн сууринаас бэлтгэгдсэн болой, **Алма** 13:3. Дэлхий бүтээгдэхээс өмнө мөнхийн уудмыг хийгээд тэнгэрийн олныг Христ харжээ, **С ба Г** 38:1. Хүн нь тэрчлэн эхлэлээс Бурхантай хамт байв, **С ба Г** 93:29 (**Хил.** 14:17; **С ба Г** 49:17). Суут сүнснүүд Сүмийн захирагчид байхаар эхлэлээс сонгогдсон болой, **С ба Г** 138:53–55.

Сүнсний дэлхийд олон нь эхнийхээ хичээлийг хүлээн авсан бөлгөө, **С ба Г 138:56**. Дэлхий дээр байхаасаа өмнө бүх зүйл сүнслэгээр бүтээгдсэн юм, **Моце 3:5**. Дэлхийг, мөн махан биед байхаас нь өмнө хүнийг би бүтээсэн юм, **Моце 6:51**. Дэлхий байхаас өмнө ухамсрууд зохион байгуулагдсан болохыг Абрахам харав, **Абр. 3:21–24**.

МӨНХИЙН ЭЦЭГ. Бурхан,
Бурхан Тэргүүтэн; Тэнгэр дэх
Эцэгийг үз

МӨРДЛӨГ ХАВЧЛАГА, МӨРДӨН ХАВЧИХ.

Бэрхшээлийг *мөн үз*

Итгэл үнэмшил хийгээд нийгмийн байдлынх нь улмаас бусдад дарамт буюу зовлон учруулах; зовоох буюу хавчих.

Зөвт байдлын төлөө хавчигдсан хүмүүс ерөөлтэй ээ! **Мат. 5:10** (3 Ниф. 12:10). Та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбир, **Мат. 5:44**. (3 Ниф. 12:44). Тэд баян учраас ядууг гадуурхдаг, **2 Ниф. 9:30** (2 Ниф. 28:12–13). Бүх мөрдлөг хавчлагыг үл хайхран, Христийг харуулдан хүлээдэг зөв шударга тэд мөхөх нь үгүй бөлгөө, **2 Ниф. 26:8**. Эдгээр бүх зүйлүүд чамайг туршлагажуулах болно, **С ба Г 122:7**.

МӨХЛИЙН ХӨВГҮҮД. Сүнсний
үхэл; Там; Уучлагдашгүй гэм
нүгэл; Чөтгөр; Ялыг *мөн үз*

Сатантай хамт үүрд мөнхөд зовох түүнийг дагагчид. Мөхлийн хөвгүүдэд (1) мөнх бус амьдралын өмнөх үед Сатаныг дагаж, тэнгэрээс хөөгдсөн хүмүүс, түүнчлэн (2) энэ дэлхийд бие махбодитой төрөхийг нь хүлээн зөвшөөрсөн боловч Сатанд үйлчилж мөн Бурханы эсрэг бүрмөсөн эргэсэн хүмүүс багтдаг. Хоёрдахь бүлгийн хүмүүс нь үхлээс амилуулагдах боловч хоёрдахь үхлээс (Сүнсний) гэтэлгэгдэхгүй бөгөөд алдар суугийн хаант улсад амьдарч чадахгүй (С ба Г 88:32, 35).

Мөхлийн хүүгээс өөр хэн ч мөхсөнгүй, **Иохан 17:12**. Тэд наманчлалд дахин шинэчлэгдэх боломжгүй юм, **Евр. 6:4–6** (Евр. 10:26–29). Хэзээ ч төгсөшгүй үргэлжлэх гарчлал болох эцсийн яланд байгаа хүнд нигүүлсэл байх эрхгүй, **Моз. 2:36–39**. Тэрээр гэтэлгэл хийгдсэн нь үгүй, **Моз. 16:5**. Христийн гайхамшгуудыг эсэргүүцэх тэд мөхлийн хүүхэд болох болно, **3 Ниф. 29:7**. Тэд энэ дэлхийд мөн дараагийнхад ч өршөөлийг хүлээн авахгүй, **С ба Г 76:30–34** (С ба Г 84:41; 132:27). Тэд бол хоёр дахь үхлээс гэтэлгэгдэхгүй байх зөвхөн тэд билээ, **С ба Г 76:34–48**. Мөхлийн хөвгүүд Ариун Сүнсийг хүлээн авсныхаа дараа эсэргүүцдэг, **С ба Г 76:35**. Мөхлийн хөвгүүд Эцэг Хүүг илчилсний дараа түүнийг эсэргүүцдэг, **С ба Г 76:43**. Каин Мөхөл хэмээн нэрлэгдэх болно, **Моце 5:22–26**.

МӨХӨЛ. Мөхлийн хүүхдүүдийг үз

МУУ ЁРЫН СҮНСНҮҮД. Сүнс—
Муу ёрын сүнснүүдийг үз

МЭДЛЭГ. Мэргэн ухаан;
Ойлголт; Үнэнийг *мөн үз*

Ойлголт ба ухаарал, ялангуяа Сүнсээр заагддаг буюу батлагддаг үнэний тухай мэдлэг.

ЭЗЭН бол мэдлэгийн Бурхан мөн, **1 Сам. 2:3**. ЭЗЭН мэдлэгт төгс билээ, **Иов 37:16**. ЭЗЭНээс эмээх нь мэдлэгийн эхлэл мөн, **Сур. үгс 1:7**. Хэлж буй үгэндээ хянамгай хүн мэдлэгтэй юм, **Сур. үгс 17:27**. Дэлхий ЭЗЭНий мэдлэгээр бялхах болно, **Иса. 11:9** (2 Ниф. 21:9; 30:15). Та нар мэдлэгийн түлхүүрийг авч явлаа, **Лук 11:52**. Христийн хайр мэдлэгийг давж гардаг, **Ефес 3:19**. Итгэл дээрээ ариун журмыг, ариун журам дээр мэдлэгийг нэмэгтүн, **2 Петр 1:5**. Нифай Бурханы сайн сайхны талаар агуу мэдлэгтэй байв, **1 Ниф. 1:1**. Тэд өөрсдийнхөө Гэтэлгэгчийн тухай мэдлэгт ирэх болно, **2 Ниф. 6:11**. Зөв шударгыг үйлдгэд нь өөрсдийнхөө зөв шударгын талаар төгс мэдлэгтэй

байх болно, **2 Ниф.** 9:14. Сүнс мэдлэгийг өгдөг, **Алма** 18:35. Тэр зүйлд та нарын мэдлэг төгс юм, **Алма** 32:34. Леменчүүд өөрсдийнхөө Гэтэлгэгчийн тухай үнэн мэдлэгт авчрагдах болно, **Хил.** 15:13. Энэ нь Бурханаас гэдгийг та нар төгс мэдлэгээр мэдэж болно, **Моро.** 7:15–17. Гэгээнтнүүд мэдлэгийн агуу сан хөмрөгийг олох болно, **С ба Г** 89:19. Цэвэр мэдлэг бодгалийг агуу ихээр өргөжүүлдэг, **С ба Г** 121:42. Ариун санваарын гүлхүүрүүдтэй түүнд баримтуудын тухай мэдлэгийг олох нь хэцүү биш, **С ба Г** 128:11. Хэрэв хүн энэ амьдралд мэдлэг хуримтлуулах аваас тэрээр ирэх дэлхийд давуу талтай байна, **С ба Г** 130:19. Үл ойшоолтод аврагдах нь боломжгүй, **С ба Г** 131:6.

МЭДРЭХ. Ариун Сүнсийг *мөн үз*

Сүнсний өдөөлтүүдийг мэдрэх.

Та нар мэдрэхээс өнгөрсөн, иймээс та нар түүний үгсийг мэдэрч чадсангүй, **1 Ниф.** 17:45. Та нар эдгээр өсөлтийг мэдрээд, энэ бол сайн үр байна хэмээн та нар хэлж эхлэх болно, **Алма** 32:28. Энэ нь зөв гэдгийг та нар мэдрэх болно, **С ба Г** 9:8. Их Эзэний өргөөнд орох бүх хүмүүс таны хүчийг мэдэрч болох буюу, **С ба Г** 109:13.

МЭРГЭН УХААН. Мэдлэг;

Ойлголт; Үнэнийг *мөн үз*

Зөвөөр шүүн тунгаах Бурханы бэлэг буюу чадвар. Хүн мэргэн ухааныг туршлага хийгээд хичээл сурлагаар дамжуулан түүнчлэн Бурханы зөвлөгөөг дагаснаар олж авдаг. Бурханы тусламжгүйгээр хүн жинхэнэ мэргэн ухаантай байдаггүй (**2 Ниф.** 9:28; 27:26).

Бурхан Соломонд мэргэн ухааныг өгчээ, **Хаад.** дээд 4:29–30. Мэргэн ухаан нь эхлэл болох зүйл: тиймээс мэргэн ухааныг олж ав, **Сур.** үгс 4:7. Мэргэн ухааныг олж авдаг нэгэн сэтгэлээ хайрлана, **Сур.** үгс 19:8. Есүс мэргэн ухаанд боловсорчээ,

Лук 2:40, 52. Хэрэв хэн нэгэн нь мэргэн ухаан дутваас, тэрээр Бурханаас асууг, **Иаков** 1:5 (С ба Г 42:68; ИС—Т 1:11). Та нар мэргэн ухааныг сурч болохын тулд би та нарт эдгээр зүйлсийг хэлж байна, **Моз.** 2:17. Залуудаа мэргэн ухааныг сур, **Алма** 37:35. Гэгээнтнүүд мэргэн ухаан болон мэдлэгийн агуу баялгийг олох болно, **С ба Г** 89:19. Өөрийгөө даруусгаснаар мөн Бурхан Их Эзэнээ дуудсанаар үл хайхрагч тэрээр мэргэн ухаанд суралцаг, **С ба Г** 136:32.

МЭРГЭН УХААНЫ ҮГ

Гэгээнтнүүдийн бие бялдрын болон сүнсний ашиг тусын төлөө Их Эзэнээр илчлэгдсэн эрүүл мэндийн хууль (С ба Г 89). Энэ нь Мэргэн Ухааны Үг хэмээн нэрлэгдэх нь нийтлэг байдаг. Их Эзэн өөрийн дагалдагчдад эрүүл мэндийн зарчмыг үргэлж заадаг байжээ. Ямар төрлийн хоол идэх, юунаас зайлсхийх хийгээд Мэргэн Ухааны Үгийг дагаснаар ирэх сүнсний болон бие бялдрын адислалуудыг Их Эзэн Иосеф Смитэд илчилжээ.

Дарс буюу хүчтэй ундаа бүү уу, **Лев.** 10:9. Дарс бол басамглагч, сархад бол агсамнагч, **Сур.** үгс 20:1. Хатуу архиийг уугчдад энэ нь гашуун болно, **Иса.** 24:9. Даниел өөрийгөө хааны хоол болон дарсаар бузарлахыг хүссэнгүй, **Дан.** 1:8. Хэрэв аливаа хүн Бурханы ариун сүмийг бузарлах аваас түүнийг Бурхан устгана, **1 Кор.** 3:16–17. Архичид Бурханы хаант улсыг өвлөхгүй, **1 Кор.** 6:10 (Гал. 5:21). Хүн мах идэхийг хориглох тэрээр Бурханаас томилогдоогүй, **С ба Г** 49:18–21. Дэлхий дээр ирэх бүх зүйлүүд бодлоготойгоор илүү байхааргүйгээр ашиглагдах ёстой, **С ба Г** 59:20. Их Эзэн Гэгээнтнүүдэд дарс, хүчтэй ундаанууд, тамхи болон халуун ундаанууд хэрэглэхгүй байхыг зөвлөжээ, **С ба Г** 89:1–9. Ургамал, жимс, амьтан болон буудай нь хүн болон амьтан ашиглахын тулд томилогдсон болой, **С ба Г** 89:10–17. Мэргэн Ухааны Үгэнд дуулгавартай

байх нь биеийн болон сүнсний адислалуудыг авчирдаг, **С ба Г** 89:18–21.

МЮЛЕК. Зедекияг *мөн үз*

Хуучин Гэрээний хаан Зедекиягийн хүү (мөө 589 оны орчимд). Зедекиягийн бүх хөвгүүд алагдсаныг Библид тэмдэглэжээ (Хаа. дэд 25:7), гэвч Мюлек амьд үлдсэнийг Мормоны Ном тодруулжээ (Хил. 8:21).

Зарахемла Мюлекийн удам байв, **Моз.** 25:2. Мюлекийн хүмүүс Нифайчуудтай нэгдэв, **Моз.** 25:13. Их Эзэн Мюлекийг умард нутагт авчрав, **Хил.** 6:10. Мюлекээс бусад Зедекиягийн бүх хөвгүүд алагдав, **Хил.** 8:21.

МЯНГАН ЖИЛ. Есүс Христийн

Хоёр дахь Ирэлт; Тамыг *мөн үз*

Христ дэлхий дээр хаанчлахаар өөрийн биеэр эргэж ирэх үед эхлэх энх амгалангийн мянган жилийн хугацаа (ИТ 1:10).

Хүмүүс илдээ далайхгүй, мөн дайтахад суралцахгүй байх болно, **Иса.** 2:4 (2 Ниф. 12:4; Мика 4:3). Энэ зэлүүд газар нь Едений цэцэрлэг адил болов, **Езек.** 36:35. Тэд Христтэй хамт мянган жилийн туршид амьдарч, хаанчилжээ, **Илч.** 20:4. Зөв шударгын улмаас Сатан хүчгүй байх болно, **1 Ниф.** 22:26. Би дэлхий дээр зөв шударга ёсонд мянган жил оршин суух болно, **С ба Г** 29:11. Тэрхүү мянган жил дуусахад биеэр дэлхийг багахан хугацаанд сул тавих болно, **С ба Г** 29:22. Тэрхүү агуу Мянган жил ирэх болно, **С ба Г** 43:30. Зөв шударгыг үйлдэгчдийн хүүхдүүд нүгэлгүйгээр өсөх болно, **С ба Г** 45:58. Хүүхдүүд өглөх хүртлээ өсөх болно; хүмүүн нүд эрмэх зуур өөрчлөгдөх болно, **С ба Г** 63:51. Долоо дахь мянган жилийн эхэнд Их Эзэн дэлхийг ариусгах болно, **С ба Г** 77:12. Тэд мянган жилийг дуусах хүртэл амьдрах нь үгүй, **С ба Г** 88:101. Сатан мянган жилийн туршид хүлэгдэх болно, **С ба Г** 88:110. Мянган жил дүрслэгдэв, **С ба Г** 101:23–34. Мянган жилийн туршид дэлхий амрах болно, **Моце** 7:64.

НААМАН. Елишаг *мөн үз*

Хуучин Гэрээнд Сирийн хааны цэргийн ахмад. Тэрээр мөн уяман өвчтэй байжээ. Нэгэн израил зарц эмэгтэй итгэлээр дамжуулан тэрээр бошиглогч Елишатай уулзахаар Израил уруу явжээ. Тэрээр өөрийгөө даруусган, бошиглогч Елишагийн зааварласны дагуу Иордан голд долоон удаа усанд орсноор уяман яраа эдгээжээ (Хаад.дэд 5:1–19; Лук 4:27).

НАЗАР. Есүс Христийг *мөн үз*

Галилын тэнгисийн баруунтаа, толгодын дундах нэг тосгон. Назар бол Есүсийн багадаа амьдарч байсан газар юм (Мат. 2:23). Есүс синагогт зааж, Исаиа 61:1–2 дахь бошиглолыг тэрээр хэрэгжүүлж байгаагаа тунхагладаг байжээ (Мат. 13:54–58; Марк 6:1–6; Лук 4:16–30).

НАЙДВАР. Итгэлийг *мөн үз*

Зөв шударга ёсны амлагдсан адислалуудын төлөө итгэлтэйгээр мөн тэвчээртэйгээр хүсэн хүлээх. Судрууд Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан мөнх амьдралыг хүсэн хүлээх явдлыг найдвар хэмээн өгүүлсэн нь олонтаа тохиолддог.

Найдвар нь Эзэн байдаг хүн ерөөлтэй эе! **Иер.** 17:7. Эзэн өөрийнхөө хүмүүсийн итгэл найдвар байх болно, **Иоел** 3:16. Тэвчээр болон судруудаар дамжин бидэнд итгэл найдвар байдаг, **Ром** 15:4. Христийн амилалтан дахь амьд найдвар уруу Бурхан биднийг төрүүлсэн билээ, **1 Петр** 1:3. Энэхүү итгэл найдвар бүхий хүн болгон өөрийгөө цэвэршүүлдэг, **1 Иохан** 3:2–3. Та нар найдварын төгс гэрэлтэйгээр урагш тэмүүлэх ёстой, **2 Ниф.** 31:20. Та нар итгэл, найдвар, мөн энэрлийг агуулж бай, **Алма** 7:24 (1 Кор. 13:13; Моро. 10:20). Та нар мөнхийн амьдралыг хүлээн авах болно гэсэн найдвартайгаар миний үгсийг сонсоосой хэмээн хүсэн би, **Алма** 13:27–29. Хэрэв та нар итгэлтэй байх аваас, та нар үнэн бөгөөд үл харагдах зүй-

лүүдэд найдах бөлгөө, **Алма** 32:21 (Евр. 11:1). Найдвар нь итгэлээр ирж, хүмүүсийн бодгальд зангуу болдог, **Ифер** 12:4 (Евр. 6:17–19). Хүмүүн найдах ёстой, эс бөгөөс тэрээр өв хүлээн авч чадахгүй, **Ифер** 12:32. Мормон итгэл, найдвар хийгээд энэрлийн тухай ярих, **Моро**. 7:1. Та нар мөнхийн амьдралд босгогдохын тулд Есүс Христийн цагаатгалаар дамжуулан найдах ёстой, **Моро**. 7:40–43. Ариун Сүнс та нарыг найдвараар дүүргэдэг, **Моро**. 8:26 (Ром 15:13). Тэд алдар суут амиуулалтын найдварт бат итгэн, мөнх бус амьдралыг орхин оджээ, **С ба Г** 138:14.

НАМАНЧЛАЛ, НАМАНЧЛАХ.

Гэмшил, Гэмших; Есүс Христ;
Нүглүүдээс ангижрах; Уучлах;
Харууссан зүрх; Цагаатгал,
Цагаатгахыг *мөн үз*

Бурханд, өөртөө болон ерөнхийдөө амьдралд хандах шинэ хандлагыг авчирдаг оюун санаа хийгээд зүрх сэтгэлийн өөрчлөлт. Наманчлал нь хүн хилэнцээс эргэж, зүрх сэтгэл хийгээд хүсэл зоригоо Бурхан уруу эргүүлж, Бурханы зарлигууд болон хүсэл эрмэлзлэлд захируулан, нүглийг орхих явдал мөн. Жинхэнэ наманчлал нь Бурханыг хайрлах хайр болон түүний зарлигуудыг дуулгавартай дагах чинхүү хүсэл эрмэлзлээс үүдэлтэй байдаг. Хариуцлагын насанд хүрсэн бүх хүмүүс нүгэл үйлдсэн байдаг бөгөөд аврал өөд дэвшихийн тулд наманчлах ёстой. Зөвхөн Есүс Христийн цагаатгалаар дамжсан үед бидний наманчлал үр ашигтай байж, Бурханаар хүлээн авагдаж болно.

ЭЗЭНД нүглээ наманчлагтун, **Езра** 10:11. Бузар муу үйлсээ зайлуул; нүгэл үйлдэхээ болигтун, **Иса**. 1:16. Наманчил, бүхий л гэм буруугаасаа өөрсдийгөө эргүүл, **Езек**. 18:30–31. Наманчлагтун та нар: учир нь тэнгэрийн хаант улс ойрхон байна, **Мат**. 3:2. Гэмшсэн нэг нүгэлтний төлөө тэнгэрт баяр хөөр болох болно, **Лук** 15:7. Газар бүрийн бүх хүмүүст на-

манчлахыг Бурхан зарлиглажээ, **Үйлс** 17:30 (2 Ниф. 9:23; 3 Ниф. 11:31–40; С ба Г 133:16). Бурханы хүслийн дагуух гашуудал нь авралд хүргэх наманчлалыг бий болгодог, **2 Кор**. 7:10. Бид цаашид хилэнцийг үйлдэх хүсэлгүй байхын тулд Бүхнийг Чадагч Их Эзэний Сүнс бидний зүрх сэтгэлд хүчирхэг өөрчлөлтийг үйлдсэн билээ, **Моз**. 5:2. Хэрэв тэр нүглүүддээ гэмшиж мөн наманчлах аваас, та нар түүнийг уучлах болно, **Моз**. 26:29. Алмаг номлосны дараа, олон хүн наманчилж эхлэв, **Алма** 14:1. Наманчлалын өдрөө бүү хойшлуулагтун, **Алма** 34:33. Өөрийн наманчлал хийгээд хөрвүүлгийн тухай Алма Хиламанд заав, **Алма** 36 (Моз. 27:8–32). Хэрэв шийтгэлгүй аваас, наманчлал хүмүүнд ирж чадах нь үгүй, **Алма** 42:16. Чамайг наманчлалд доош авчрах тэр зовлонгоор нүглүүд чинь чамайг зовоог, **Алма** 42:29. Харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийг та нар надад тахил болгон өргөх болно, **3 Ниф**. 9:20. Наманчилж мөн бяцхан хүүхдийн адил надад ирэх хэнийг боловч би түүнийг хүлээн авах болно, **3 Ниф**. 9:22. Ертөнцийн хязгаарууд та нар бүгд наманчлагтун, **3 Ниф**. 27:20. Тэд наманчлах болгондоо өршөөгддөг байлаа, **Моро**. 6:8. Энэ үеийнхэнд наманчлалаас өөр юу ч бүү ярь, **С ба Г** 6:9 (С ба Г 11:9). Наманчилдаг бодгаль дахь түүний баяр хөөр хичнээн агуу билээ! **С ба Г** 18:13. Хүн болгон наманчлах буюу хүлцэн тэвчих ёстой, **С ба Г** 19:4. Нүгэл үйлдэж, мөн наманчилдаггүй тэрээр, зайлуулагдах болно, **С ба Г** 42:28. Гэмшиж мөн нүглүүдээс орхидог тэрээр өршөөгддөг, **С ба Г** 58:42–43. Наманчлах нас барагсад гэтэлгэгдэх болно, **С ба Г** 138:58. Наманчлалд бид итгэдэг, **ИТ** 1:4.

НАОМИ. Рутыг *мөн үз*

Хуучин Гэрээнд зөв шударга эмэгтэй мөн Елимелекийн эхнэр (Рут 1–4). Елимелек Наоми хоёр өлсгөлөнгөөс зугтаахын тулд гэр

бүлээ Моаб уруу аваачжээ. Елимелек болон түүний хоёр хүү нас барсны дараа, Наоми бэр Рутынхээ хамт Бетлехемд эргэж иржээ.

НАС БАРАГСДЫН АВРАЛ.

Аврал; Гэтэлгэлийн төлөвлөгөө; Дурсамжийн ном; Удмын бичгийг *мөн үз*

Сайн мэдээний аврах ёслолуудыг хүлээн авалгүйгээр нас барсан хүмүүсийн төлөө эдгээр ёслолуудыг ариун сүмүүдэд Сүмийн амьд зохистой гишүүд гүйцэтгэх боломж. Нас барагсад нь сайн мэдээг сүнсний дэлхийд заалгуулах бөгөөд тэдний төлөө гүйцэтгэгдсэн ёслолуудыг хүлээн авч болох юм.

Эцэг өвгөдийнх нь төлөө аврах ёслолууд гүйцэтгэгдэж болохын тул Сүмийн итгэлтэй гишүүд гэр бүлийн түүхээ судлан мөн бэлтгэж нэрс болон төрсөн он сар өдрийг тогтоодог.

Хоригдлуудад Урагш явцгаа хэмээн хэл, **Иса.** 49:9 (Иса. 24:22; 1 Ниф. 21:9). Боолчлогдогсдод эрх чөлөөг тунхагла, **Иса.** 61:1 (Лук 4:18). Тэрээр эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүд уруу нь эргүүлнэ, **Малах.** 4:5–6 (3 Ниф. 25:5–6; С ба Г 110:13–16). Нас барагсад Бурханы Хүүгийн дуу хоолойг сонсох болно, **Иохан** 5:25. Тэгвэл тэд яагаад нас барагсдын тул баптисм хийдэг вэ? **1 Кор.** 15:29. Христ шоронд сүнснүүдэд заав, **1 Петр** 3:18–20. Учир нь энэ шалтгааны улмаас нас барагсдад сайн мэдээ номлогдсон билээ, **1 Петр** 4:6. Хүү шоронд сүнснүүд дээр зочлов, **С ба Г** 76:73. Тэгээд өөрсдийнхөө хувийг шоронд хүлээн авсан тэдний гэтэлгэл ирнэ, **С ба Г** 88:99. Миний Гэгээнтнүүд нас барсан тэдний өмнөөс баптисм хүртэх баптисмын сан дэлхий дээр байхгүй байна, **С ба Г** 124:29. Сайн мэдээг хүлээн зөвшөөрөх тэдгээр бүх нас барагсад селестиел хаант улсыг өвлөгчид болно, **С ба Г** 137:7–10. Итгэлтэй байсан боолчлогдогсдод Бурханы Хүү үзэгдэж эрх чөлөөг тунхаглав, **С ба Г** 138:18.

Шоронд байсан сүнснүүдээс олон нь урагш гарч иржээ, **Моце** 7:57.

НАТАН. Давидыг *мөн үз*

Хаан Давидын үед байсан Хуучин Гэрээний бошиглогч. Их Эзэнд зориулан ариун сүм барихаар Давидыг санал болгоход тэрээр үүнийг бариагүйг Давидад хэл хэмээн Их Эзэн Натанд зааварлажээ. Натан түүнчлэн түүний дайчдын нэг Уриагийн үхэл хийгээд Уриагийн эхнэр Батшебаг авсан тухайд Давидыг зэмлэжээ (2 Сам. 12:1–15; С ба Г 132:38–39). Натаны хамт Задок Давидын хүү Соломон хааныг тосоор адисалжээ (Хаад. дээд. 1:38–39, 45).

НАТАНАЕЛ. Бартоломейг *мөн үз*

Шинэ Гэрээнд Христийн нэг төлөөлөгч бөгөөд Филиппийн найз (Иохан 1:45–51. Тэрээр Галил дахь Каньын хүн байв (Иохан 21:2). Натанаел бол ов мэхгүй изриал хүн байсан хэмээн Христ хэлжээ (Иохан 1:47). Бартоломей тэр хоёр ерөнхийдөө адилхан байжээ гэж бодогддог (Мат. 10:3; Марк 3:18; Лук 6:14; Иохан 1:43–45).

НАУВУ, ИЛЛИНОЙ (АНУ)

Иллиной муж улсад 1839 онд Хожмын Үеийн Гэгээнтнүүээр үндэслэгдсэн хот. Энэ хот Миссури мөрний эрэгт, Сейнт Люисээс мөрнийг өгсөн дээш хоёр зуу шахам миль (320 км)-д байлаг.

Миссури муж улс дахь мөрдлөг хавчлагын улмаас Гэгээнтнүүд Миссури мөрнийг гатлан зүүн хойш хоёр зуун миль орчимд Иллиной уруу шилжин нүүж, тийнхүү тэнд тэд илүү ая тухтай нөхцөлийг олжээ. Эцэст нь, Гэгээнтнүүд хөгжөөгүй хот Коммерсын ойролцоо газар худалдаж авав. Энэ бол маш их намгархаг, хэдхэн энгийн барилгатай зэлүүд газар байлаа. Гэгээнтнүүд газрыг хатааж, дараа нь байшин барьж байв. Иосеф Смит гэр бүлээ жижигхэн дүнзэн байшинд нүүлгэн аваачив. Коммерс хотын нэр,

“үзэсгэлэнт” гэсэн утгатай еврей үгээр Науву хэмээн өөрчлөгджээ.

Сургаал ба Гэрээний хэд хэдэн хэсэг Наувуд цэдэгдсэн ажээ (С ба Г 124–129, 132, 135). Наувуд ариун сүм барь хэмээн Гэээнтнүүдэд хэлжээ (С ба Г 124:26–27). 1846 онд Гэгээнтнүүд хөөгдөхөөсөө өмнө ариун сүм барьж мөн Сионы гадаснуудыг зохион байгуулсан байлаа. Энэхүү мөрдлөг хавчлагын улмаас, Гэгээнтнүүд уг нутгийг орхин өрнөд уруу аянд гарсан ажээ.

НАФТАЛИ. Израил; Иаков, Исаакийн хүүг мөн үз

Иаковын арванхоёр хүүгийн тав дахь нь буюу Рахелын зарц Билхагийн хоёр дахь хүүхэд (Эхл. 30:7–8). Нафтали дөрвөн хүүтэй байжээ (Шаст. дээд 7:13).

Нафталлийн овог: Нафталийг адисалсан Иаковын адислал Эхлэл 49:21-д тэмдэглэгдсэн байдаг. Энэ овгийг адисалсан Мосегийн адислал Дэд Хуулийн 33:23-т тэмдэглэгджээ.

НАХУМ

мэ 642 болон 606 оны хооронд өөрийн бошиглолуудыг цэдэглэж байсан Хуучин Гэрээн дэх Галилын бошиглогч.

Нахумын ном: Бүлэг 1 нь Хоёр дахь Ирэлтийн үеэр дэлхий шатах болон Их Эзэний хийгээд бүх хүчний тухай өгүүлдэг. Бүлэг 2 нь Ниневегийн устгалын тухай өгүүлдэг бөгөөд энэ нь хожмын өдрүүдэд тохиох үйл явдлуудын дохио болдог. Бүлэг 3 нь Ниневегийн гунигт устгалыг угтан хэлэхээ үргэлжлүүлдэг.

НЕБУХАДНЕЗАР. Бабел, Вавилон; Даниелыг мөн үз

Хуучин Гэрээнд Иудейг байлдан дагуулж (Хаад. дэд 24:1–4), мөн Иудейг бүсэлсэн (Хаад. дэд. 24:10–11) Вавилоны хаан (мэ 604–561). Хаан Зедекиаг болон хүмүүсийг нь Небухаднезар авч явахад, бошиглогч Лихай Вавилонд боолчлолд аваачигдахаас

зайлсхийхийн тулд (1 Ниф. 1:4–13) Иерусалимаас зугтахаар мэ 600 оны орчимд зарлиг болгогджээ (Хаад. дэд. 25:1, 8–16, 20–22). Даниел Небухаднезарын зүүдийг тайлжээ (Дан. 2; 4).

НЕХЕМИА

Хуучин Гэрээнд, Вавилонд Артаксерксын ордонд сөнчийн албан тушаал хашиж байсан язгууртан израил хүн, тэрээр Иерусалемын хэрмийг дахин барих эрхийг өөрт нь олгосон хааны зөвшөөрлийг Артаксерксаас олж авчээ.

Нехемиагийн ном: Энэ ном бол Езрагийн номны үргэлжлэл юм. Энэ нь иудейчүүд Вавилоны боолчлолоос эргэж ирсний дараах Иерусалим дахь ажлын өсөлт дэвшил хийгээд хүндрэл бэрхшээлүүдийн тухай шастирыг агуулдаг. Бүлэг 1–7 нь Нехемиа Иерусалемд анх удаа ирсэн тухай хийгээд агуу эсэргүүцлийг үл хайхран хотын хэрмийг дахин барьсан тухай өгүүлдэг. Бүлэг 8–10 нь Нехемиагийн хэрэгжүүлэхээр хичээж байсан шашны болон нийгмийн шинэчлэлүүдийг дүрсэлдэг. Бүлэг 11–13 нь зохистой хүмүүсийн нэрсийг дурдаж, хэрмийг онцгойлон адисалсан тухай шастирыг өгүүлдэг. Бүлэг 13-ын шүлэг 4–31 нь хорин жил алс хол байсны дараа Нехемиа хоёр дахь удаагаа Иерусалемд ирсэн тухай өгүүлдэг.

НИГҮҮЛСЭЛ, НИГҮҮЛСЭНГҮЙ.

Ач ивээл; Есүс Христ; Өршөөх; Цагаатгал, Цагаатгах; Шударга ёсыг мөн үз

Өрөвч зөөлөн, энэрэнгүй сэтгэл, мөн өршөөлийн сүнс. Нигүүлсэл нь Бурханы шинж чанаруудын нэг мөн. Есүс Христ өөрийн цагаатгагч золиослолоор дамжуулан бидэнд нигүүлслийг үзүүлдэг.

Эзэн Бурхан өрөвч, нигүүлсэнгүй билээ, Ег. 34:6 (Дэд хууль. 4:31). Түүний хайр энэрэл үүрдийнх,

Шаст. дээд. 16:34. Сайн сайхан хийгээд хайр энэрэл намайг дагана, **Дуул.** 23:6. Ядуу хүнд нигүүлсэнгүй хандагч хүн ерөөлтэй, **Сур.** үгс 14:21. Би тахилаас илүүгээр хайр энэрэлд баярладаг, **Хосеа** 6:6. Энэрэнгүй хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд өршөөл энэрлийг хүртэх болно, **Мат.** 5:7 (3 Ниф. 12:7). Аравны нэгийг төлдөг атлаа хуулийн илүү чухал асуудлууд, шүүлт, нигүүлсэл, итгэлийг орхигдуулдаг хоёр нүүртнүүд золгүй еэ, **Мат.** 23:23. Та нарын Эцэг өршөөнгүй. Түүнчлэн өршөөнгүй байгтун, **Лук** 6:36. Тэр биднийг зөвт байдлын дотор хийсэн үйлсээр минь бус, харин Өөрийнхөө өршөөлийн дагуу биднийг аварсан юм, **Тит** 3:5. Их Эзэний өрөв зөөлөн нигүүлсэл бүхний дээр байдаг, **1 Ниф.** 1:20. Үл наманчлагч дээр нигүүлсэл байх эрхгүй болой, **Моз.** 2:38–39. Бурхан бол түүний нэрэнд итгэдэг бүгдэд нигүүлсэнгүй билээ, **Алма** 32:22. Нигүүлсэл нь тийн шударга ёсны шаардлагыг хангадаг, **Алма** 34:16. Нигүүлсэл нь шударга ёсыг дээрэмдэж болно хэмээн чи бодно уу? **Алма** 42:25 (Алма 42:13–25). Бяцхан хүүхдүүд түүний нигүүлслийн улмаас Христэд амьд бөлгөө, **Моро.** 8:19–20 (С ба Г 29:46). Есүс Христийн нигүүлслийн мутар бидний нүглүүдийг цагаатгасан билээ, **С ба Г** 29:1. Өөрийн урсгасан цусны ариун журмаар бибээр миний нэрэнд итгэдэг тэднийг Эцэгийн өмнө өмгөөлөн гуйсан бөлгөө, **С ба Г** 38:4. Гэрээг сахисан тэд нигүүлслийг олох болно, **С ба Г** 54:6. Их Эзэн бибээр нүглүүдийг өршөөдөг, мөн өөрсдийн нүглийг даруу зүрх сэтгэлээр гэмшдэг тэдэнд нигүүлсэнгүй билээ, **С ба Г** 61:2. Их Эзэн бибээр бүх номхон дөлгөөнчүүдэд нигүүлслийг үзүүлдэг, **С ба Г** 97:2. Мөн чамайг бяцхан хүүхэд мэтээр хэн хүлээн авна, миний хаант улсыг хүлээн авдаг, учир нь тэд нигүүлслийг олох болно, **С ба Г** 99:3. Нигүүлсэл чиний нүүрний өмнө явах болно, **Моце** 7:31.

НИЙТИЙН ДЭМЖЛЭГ. Есүс

Христийн Сүм, Сүмийн удирдагчдыг дэмжихийг мөн үз

Энэ нь Сүмийн гишүүд Сүмд үйлчлэхээр дуудагдсан хүмүүсийг дэмжих болон тэдний дэмжлэг шаардагдах Сүмийн бусад шийдвэрүүд дээр ихэнхдээ баруун гараа өргөж харуулах зарчим юм.

Есүс Христ Сүмийнхээ тэргүүн болон зогсдог. Ариун Сүнсний нөлөөллөөр дамжуулан тэрээр чухал ажил үйлс болон шийдвэрүүдэд Сүмийн удирдагчдыг чиглүүлдэг. Хэдий тийм ч, Сүмийн бүх гишүүд удирдагчдынхаа ажил үйлс болон шийдвэрүүдийг дэмжих болон дэмжихгүй байх эрхтэй мөн ийм боломжтой байдаг.

Хүн бүхэн нэгэн дуу хоолойгоор хариулав, **Ег.** 24:3 (Тоол. 27:18–19). Төлөөлөгчид болон ахлагч нар хамтдаа санаа нэгдэв, **Үйлс** 15:25. Сүмийн саналгүйгээр нэг ч хүн томилогдохгүй, **С ба Г** 20:65–66. Бүх зүйл нийтийн дэмжлэгээр хийгдэх ёстой, **С ба Г** 26:2 (С ба Г 28:13). Бүх зүйл нийтийн дэмжлэгээр хийгдэг, **С ба Г** 104:21.

НИКОДЕМ. Фарисайчуудыг мөн үз

Шинэ Гэрээнд, иудейчүүдийн зөв шударга удирдагч (Санхедриных бололтой) мөн фарисай хүн юм (Иохан 3:1).

Тэрээр Есүстэй шөнө дунд ярив, **Иохан** 3:1–21. Тэрээр Христийг фарисайчуудаас хамгаалав, **Иохан** 7:50–53. Тэрээр Есүсийн оршуулгад халуун ногоонууд авчрав, **Иохан** 19:39–40.

НИНЕВЕ. Ассири; Ионаг мөн үз

Хуучин Гэрээнд, Ассирийн нийслэл бөгөөд хоёр зуу гаруй жилийн туршид Тигр мөрний зүүн эрэг дэх арилжаа наймааны том төв байв. Энэ хот мээ 606 онд Ассирийн эзэнт гүрэн мөхөхөд унажээ.

Ассирийн хаан Сеннахериб Ниневед амьдарч байв, **Хаад.** дэд 19:36.

Хотыг наманчлалд дуудахаар Иона илгээгджээ, **Иона** 1:1–2 (Иона 3:1–4). Ниневегийн хүмүүс наманчлав, **Иона** 3:5–10. Ниневег Христ иудейчүүдийн өмнө наманчлалын үлгэр жишээ болгон ашиглаж байв, **Мат.** 12:41.

НИФАЙ, ЛИХАЙН ХҮҮ. Нифайн эцэг, Лихай; Нифайчуудыг мөн үз

Мормоны Номонд, Лихай, Сарай хоёрын зөв шударга хүү (1 Ниф. 1:1–4; 2:5). Бурханы үгэнд Нифай хүчтэй итгэж байсан (1 Ниф. 3:7) бөгөөд агуу бошиглогч, цэдэг хөтлөгч, мөн өөрийнхөө хүмүүсийн агуу удирдагч болсон билээ.

Дуулгавартай байж мөн итгэлд залбирдаг байв, **1 Ниф.** 2:16. Ээс ялтсуудыг авахаар Иерусалем уруу буцав, **1 Ниф.** 3–4. Ишмэилийн гэр бүлийнхнийг аглаг буйдаа аваачихаар Иерусалем уруу буцав, **1 Ниф.** 7. Лихай хүлээж авсан мөнхүү тэр үзэгдлийг хүлээн авав, **1 Ниф.** 10:17–22; 11. Өөрийн хүмүүсийн ирээдүйг хийгээд сайн мэдээний сэргээлтийг үзэгдэлд харав, **1 Ниф.** 12–13. Амьдралын модны үзэгдлийг тайлав, **1 Ниф.** 15:21–36. Нумаа хугалсан хэдий ч итгэлээр дамжуулан хоол хүнс олох боломжтой байв, **1 Ниф.** 16:18–32. Хөлөг онгоц барьж мөн амлагдсан нутгийн зүг аялав, **1 Ниф.** 17–18. Нифай болон Леменчүүд тусгаарлагдав, **2 Ниф.** 5. Гэрчлэлээ хэлэв, **2 Ниф.** 33.

1 Нифайн ном: Бүлэг 1-ээс 18:8 нь Иерусалимыг орхин явж буй Лихай болон түүний гэр бүлийн талаар ихэвчлэн өгүүлдэг. Тэд далайд хүртлээ үржил шимгүй цөл дундуур аялжээ. 1 Нифай 18:9–23 нь Лемен, Лемүел хоёрын эсэргүүцлийг үл хайхран, Их Эзэнээр чиглүүлэгдсэний дагуу, амлагдсан нутгийн зүг хийсэн тэдний аяллын тухай өгүүлдэг. Бүлэг 19–22-т Нифайн цэдэг хөтөлсөн зорилго, өөрсдийн Гэтэлгэгч Их Эзэнийг дурсан санахыг бүгдэд сэнхрүүлэн ойлгуулах явд-

лыг өгүүлдэг (1 Ниф. 6:1–6; 19:18). Есүс Христ бол тэдний Аврагч хийгээд Гэтэлгэгч болохыг бүгдээрээ мэдэж болох юм гэсэн найдвартайгаар тэрээр Исаиаг (1 Ниф. 20–21) болон захиасуудыг иш татсан байдаг (1 Ниф. 22:12).

2 Нифайн ном: Бүлэг 1–4 нь, нас барахынх нь өмнөх Лихайн сүүлчийн сургаалууд хийгээд бошиглолууд, түүний дотор өөрийн хөвгүүд болон тэдний үр удам дээрх адислалуудын заримыг нь агуулсан байдаг. Бүлэг 5 нь нифайчууд яагаад өөрсдийгөө леменчүүдээс тусгаарласныг тайлбарладаг. Нифайчууд ариун сүм барьж, Мосегийн хуулийг заан мөн цэдгүүд хөтөлж байлаа. Бүлэг 6–10 Нифайн дүү Иаковын үгсийг агуулдаг. Иаков иудейчүүдийн түүхийг нэгтгэн дүгнэж, Мессиагийн тухай бошиглосны зарим нь бошиглогч Исаиагийн бичээсүүдээс авагдсан байлаа. Бүлэг 11–33-т Есүс Христийн тухай өөрийн гэрчлэл, Иаковын гэрчлэл, эцсийн өдрүүдийн тухай бошиглолууд хийгээд Хуучин Гэрээний Исаиагийн номны хэд хэдэн бүлгийг цэдэглэжээ.

Нифайн ялтсууд: Ялтсуудыг үз

НИФАЙ, ХИЛАМАНЫ ХҮҮ,
НИФАЙН ХҮҮ. Нифай,
Хиламаны хүү; Шавийг мөн үз

Мормоны Номонд, амилсан Есүс Христээр сонгогдсон нифайчуудын арванхоёр шавийн нэг (3 Ниф. 1:2–3; 19:4). Энэ бол өөрийн хүмүүсийн нэрийн өмнөөс Их Эзэнд хүчтэйгээр залбирдаг байжээ. Нифай Их Эзэний дуу хоолойг сонсдог байв (3 Ниф. 1:11–14). Түүнд Нифай тэнгэр элчүүдээр айлчлагдан, чөтгөрүүдийг зайлуулж, ахыгаа нас барагсдаас босгон, мөн итгэхгүй байхын аргагүй гэрчлэлийг хэлдэг байлаа (3 Ниф. 7:15–19; 19:4). Нифайн цэдэг хөтөлдөг байв (3 Ниф. 1:2–3).

3 Нифайн ном: Нифайн хүү Нифайгаар бичигдсэн Мормоны Номон

доторх нэг ном. Бүлэг 1–10 нь Их Эзэний ирэлтийн талаарх бошиглолуудын биелэлтийг харуулдаг. Христийн төрөлтийн тэмдэг өгөгдсөн бөлгөө; хүмүүс наманчлав; гэвч дараа нь тэд ёсон бус уруу дахин эргэв. Эцэст нь хуй салхинууд, газар хөдлөлтүүд, хүчтэй шуургууд мөн агуу үгүйрэл Христийн үхлийн дохио болов. Бүлэг 11–28 нь Христ Америк тивд ирснийг цэдэглэдэг. Энэ бол 3 Нифайн номны төв хэсэг мөн. Христийн олон үг Библид тэмдэглэгдсэн түүний номлолтой төстэй юм (Жишээ нь, Мат. 5–7 болон 3 Ниф. 12–14). Бүлэг 29–30 нь хожмын үеийн үндэстнүүдэд хандсан Мормоны үгс юм.

4 Нифайн ном. Энэ ном ердөө дөчин есөн шүлэгтэй, бүгдээрээ ганцхан бүлэгт байдаг ч гэсэн энэ нь нифайчуудын түүхийн ойролцоогоор гурван зуун жилийг хамардаг (мэ 34–321 он). Зохиогчдын хэд хэдэн үеийнхэн, түүний дотор Нифай уг цэдэгт хувь нэмрээ оруулсан байна. Шүлэг 1–19 нь амилсан Христийн айлчлалын дараа нифайчууд хийгээд леменчүүд бүгдээрээ сайн мэдээнд хөрвүүлэгдсэн тухай өгүүлдэг. Энх амгалан, хайр, түүнчлэн эв нийц ноёрхож байлаа. Христ өөрийн хоёр дахь ирэлтийг хүртэл дэлхий дээр үлдэхийг нь зөвшөөрсөн (3 Ниф. 28:4–9), гурван нифай шавь хүмүүст тохинуулж байв. Нифай цэдгийг хүү Амосаа үлдээжээ. Шүлэг 19–47 нь Нифай хийгээд (84 жил) мөн түүний хүү Амосын (112 жил) тохинууллын цэдэг юм. мэ 201 онд бардамнал хүмүүсийн дунд асуудлууд бий болгож, тэд өөрсдийгөө ангиудад хуваан мөн хуурамч сүмүүд ашиг олж эхэлжээ (4 Ниф. 1:24–34).

4 Нифайн сүүлчийн шүлгүүд нь хүмүүс ёс буст дахин эргэснийг харуулдаг (4 Ниф. 1:35–49). мэ 305 онд хүү Амос нас барж түүний ах Аммарон бүх ариун нандин цэдгүүдийг аюулгүй хадгалахын тулд нуужээ. Хожим нь Аммарон цэдгүүдийг Мормонд итгэл хүлээлгэн өгч,

тэрээр амьдралынхаа олон үйл явдлыг цэдэглэж, дараа нь тэдгээрийг хураангуйлан тэмдэглэжээ (Морм. 1:2–4).

НИФАЙ, ХИЛАМАНЫ ХҮҮ.

Лихай, Нифай номлогч;

Хиламан, Хиламаны хүүг *мөн үз*

Мормоны Номон дахь нифайчуудын агуу бошиглогч хийгээд номлогч.

Хиламаны ууган хүү байв, **Хил.** 3:21. Ерөнхий шүүгчээр томилгогдов, **Хил.** 3:37. Тэр болон түүний ах Лихай олон леменчүүдийг сайн мэдээнд хөрвүүлэв, **Хил.** 5:18–19. Галаар хүрээлэгдэж мөн шоронгоос суллагдав, **Хил.** 5:20–52. Өөрийн цэцэрлэгт цамхаг залбирав, **Хил.** 7:6–10. Ерөнхий шүүгч алагдсаныг илчлэв, **Хил.** 8:25–28; 9:1–38. Их Эзэнээр агуу хүч өгөгдөв, **Хил.** 10:3–11. Өлсгөлөнг мөн уг өлсгөлөнгийн төгсгөлийг Их Эзэнээс хүсэв, **Хил.** 11:3–8.

НИФАЙ ШАВЬ НАР.

Гурван нифай шавийг үз

НИФАЙЧУУД.

Леменчүүд;
Мормоны Ном; Нифай, Лихайн хүүг *мөн үз*

Мормоны Номон дахь хэсэг хүмүүс, тэднээс олон нь Лихайн хүү, бошиглогч Нифайн удмынхан байв. Тэд леменчүүдээс тусгаарлаж, түүнчлэн ерөнхийдөө леменчүүдээс илүү зөв шударга байв. Гэсэн хэдий ч, ёс бусын улмаас тэд эцэстээ леменчүүдээр устгагдсан билээ.

Нифайчууд леменчүүдээс тусгаарлав, **2 Ниф.** 5:5–17. Леменчүүд биш байсан тэд бүгд нифайчууд байв, **Иаков** 1:13. Нифайчууд илүү зөв зорилгоор урамшуулагдсан байв, **Алма** 43:6–9, 45. Нифайчууд Моронайн үеийнхээс хэзээ ч илүү аз жаргалтай байсангүй, **Алма** 50:23. Зөв шударга хүмүүсийн залбирлын учир нифайчууд аврагдсан байлаа, **Алма** 62:40. Нифайчууд итгэлгүйдээ бууран доройтож эхлэв, **Хил.** 6:34–35. Есүс нифайчуудын дунд зааж мөн

тохинуулж байв, **3 Ниф.** 11:1–28:12. Бүгд Их Эзэнд хөрвүүлэгдэж мөн бүх зүйл нийтийнх байв, **4 Ниф.** 1:2–3. Зөрчилдөөн огт байсангүй, Бурханы хайр тэдний зүрх сэтгэлд оршиж байв, мөн тэд хүмүүсээс хамгийн аз жаргалтай нь байв, **4 Ниф.** 1:15–16. Нифайчууд бардам хийгээд хоосон сагсуурдаг болж эхлэв, **4 Ниф.** 1:43. Цус мөн хядаан бүх нутгийн гадаргуу дээгүүр тархав, **Морм.** 2:8. Нифайчууд ёс бусдаа өсөн нэмэгдэж мөн Мормон тэднийг удирдахаас татгалзав, **Морм.** 3:9–11. Бүх нифайчууд, хорин дөрвөөс бусад нь алагдав, **Морм.** 6:7–15. Христийг үгүйсгээгүй нифайчуудыг үхэлд хүргэж байв, **Моро.** 1:2. Өөрсдийн ёс бус явдал хийгээд нүглүүдийн учир нифайчууд устгагдсан бөлгөө, **С ба Г** 3:18. Та нар нифайчуудын адил болохгүйн тулд бардамналаас болгоомжлогтун, **С ба Г** 38:39

НИХОР. Христийг эсэргүүцэгч;

Хуурмаг санваарыг мөн үз

Мормоны Номон дахь хилэнцэт нэгэн. Нихор бол нифайчуудын дунд хуурмаг санваарыг анхлан хэрэглэгчдийн нэг байв. Хуурмаг сургаал зааж мөн Гидеоныг алсны дараа Нихор өөрийн гэмт хэргүүдийн учир цаазаар аваачигджээ (Алма 1). Нихорыг дагалдагчид түүний хилэнцэт үйлийг хийгээд сургаалуудыг Нихорыг үхсэнээс хойш удтал үргэлжлүүлжээ.

Нихорын жаягийн дагуух шүүгчээр Алма, Амюлек хоёр шоронд хоригдов, **Алма** 14:14–18. Алагдсан тэд Нихорын адил бодолтой байжээ, **Алма** 16:11. Олон нь Нихорын жаягийн дагуу байв, **Алма** 21:4. Ах дүүсээ алсан тэдний хамгийн олон тоотой нь нихорчуудын жаягийн дагуух хүмүүс байв, **Алма** 24:28.

НОА, БИБЛИЙН ПАТРИАРХ.

Габриел; Ноагийн үеийн үер;

Солонго; Хөвөгч авдрыг мөн үз

Хуучин Гэрээнд Ламехын хүү түүнчлэн Адамаас хойш арав дахь

патриарх (Эхл. 5:29–32). Тэрээр Христийн тухай гэрчилж мөн ёс бус үеийнхэнд наманчлалыг номлож байлаа. Түүний захиасыг хүмүүс эсэргүүцэхэд, ёс бусчуудыг устгахаар дэлхий үерлэхэд өөрийн гэр бүл хийгээд бүх амьтдыг байрлуулах хөвөгч авдар барихыг Бурхан түүнд зарлиглажээ (Эхл. 6:13–22; Мосе 8:16–30). Ноа бол тэнгэр элч Габриел бөгөөд авралын түлхүүрүүдийг атгахад Адамын дараа ордог хэмээн бошиглогч Иосеф Смит заасан байдаг.

Бурханы зарлигаар тэд хөвөгч авдар барихад тэр болон түүний хөвгүүд Иафет, Шем, Хам нар түүнчлэн тэдний эхнэрүүд аврагджээ, **Эхл.** 6–8 (Евр. 11:7; 1 Петр. 3:20). Их Эзэн Енохтой хийсэн гэрээг Ноатай болгон шинэчлэв, **Эхл.** 9:1–17 (Мосе 7:49–52; ИСО, Эхл. 9:15, 21–25). Ноа арван настай байхдаа Метуселагаар санваарт томилогджээ, **С ба Г** 107:52. Хүмүүс түүний амийг авахаар оролдож байсан хэдий ч, Бурханы хүч түүнийг аврав, **Мосе** 8:18. Тэрбээр зөв шударга ёсыг номлогч болж мөн Есүс Христийн сайн мэдээг зааж байв, **Мосе** 8: 19, 23–24 (2 Петр. 2:5).

НОА, ЗЕНИФИЙН ХҮҮ

Мормоны Номон дахь ёс бус хаан. Тэрээр Нифайн нутаг дахь хэсэг нифайчуудыг захирч байв.

Ноа олон нүгэл үйлдэв, **Моз.** 11:1–15. Бошиглогч Абинадаг тэрээр алахыг тушаав, **Моз.** 13:1 (Моз 17:1, 5–20). Ноа шатаагдаж үхэв, **Моз.** 19:20.

НОАГИЙН ҮЕ ДЭХ ҮЕР. Библийн

Патриарх, Ноа; Солонго;

Хөвөгч авдрыг мөн үз

Ноагийн үед дэлхий усаар бүрмөсөн бүрхэгдсэн байв. Энэ бол дэлхий баптисм хүртсэн бөгөөд цэвэршилтийн бэлэгдэл болдог (1 Петр 3:20–21).

Бурхан газар дэлхий дээр үер буулгаж бүх махан биеийг устгах болно,

Эхл. 6:17 (Моисе 7:34, 43, 50–52; 8:17, 30). Үерийн ус дэлхийд буув, **Эхл.** 7:10. Би гэрээний тэмдэг болгож үүлэнд солонго татуулна, **Эхл.** 9:9–17. Үерийн ус ширгэсний дараа Америкийн нутаг сонгосон нутаг болов, **Ифер** 13:2. Ёс бусчууд үерт мөхөх болно, **Моисе** 7:38; 8:24.

НОЙРСОХ, УНТАХ

Хүн идэвхгүй буюу сэргэг бус байх нь амралтын үеийн байдал. Шаардлагагайгаас илүү бүү унт хэмээн Их Эзэн өөрийн Гэгээнтнүүдэд зөвлөжээ (С ба Г 88:124). Унтах нь тэрчлэн сүнсний үхлийн (1 Кор. 11:30; 2 Ниф. 1:13) эсвээс бие махбодийн үхлийн (Морм. 9:13) бэлэгдэл болдог.

НОМЛОГЧИЙН АЖИЛ. Сайн мэдээ; Номлохыг мөн үз

Есүс Христийн сайн мэдээг үг хийгээд үлгэр дууриаллаар хуваалцах.

Авралыг тунхаглагч түүний хөл уулсын дээр ямар үзэсгэлэнтэй вэ?, **Иса.** 52:7. Би өөрийн хонинуудыг өөрөө хайж мөн тэднийг олох болно, **Езек.** 34:11. Бүх дэлхийгээр явж, Сайн мэдээг бүх бүтээлд тунхаглагчун, **Марк** 16:15 (Морм. 9:22). Талбай цайрч хураалтанд бэлэн болжээ, **Иохан** 4:35. Илгээгдэхээс нааш тэд яаж номлох вэ?, **Ром** 10:15. Бурханы үгийг тэдэнд бүхий л хичээл зүтгэлээр заагчун, **Иаков** 1:19. Их Эзэн өөрийн үгийг бүх үндэстнүүдэд заахыг өгдөг болой, **Алма** 29:8. Сайн мэдээ нь сул доройчууд хийгээд эгэл борчуудаар тунхаглагдаж болох буюу, **С ба Г** 1:23. Гайхамшигт ажил тохиох гэж байна, **С ба Г** 4:1. Хэрэв та нар өөрсдийн бүхий л өдрүүдэд хөдөлмөрлөж, мөн зөвхөн нэг бодгалийг надад авчрах аваас, та нарын баяр хөөр хичнээн агуу байх билээ, **С ба Г** 18:15. Миний сонгосон хүмүүс дуу хоолойг минь сонсож мөн зүрх сэтгэлээ хатууруулах нь үгүй болой, **С ба Г** 29:7. Миний сайн мэдээг номлон, хоёр хоёроороо урагш одогчун, **С ба Г** 42:6. Уг дуу

хоолой энэ газраас урагш одох ёстой, **С ба Г** 58:64. Миний сайн мэдээг тунхаглахад амаа нээгчүн, **С ба Г** 71:1. Зарлигууд хийгээд илчлэлтүүдийн дагуу үнэнийг тунхаглагчун, **С ба Г** 75:4. Сэрэмжүүлэгдсэн хүн болгон хөршийгөө сэрэмжлүүлэх ёстой, **С ба Г** 88:81 (С ба Г 38:40–41). Сайн мэдээг номлох тэдний гэр бүлүүдийг Их Эзэн хангах болно, **С ба Г** 118:3. Бурханы үйлчлэгчид урагш одох ёстой, **С ба Г** 133:38. Итгэлтэй ахлагчид мөнх бус амьдралаас халин одоод, өөрсдийн хөдөлмөрийг үргэлжлүүлдэг билээ, **С ба Г** 138:57.

НОМЛОГЧИЙН ҮГС

Амьдралын зарим гүн гүнзгий асуудлуудын талаарх үзэл баримтлалуудыг агуулсан Хуучин Гэрээний ном.

Номыг зохиогч, номлогч нь номын ихэнхийг сайн мэдээний ойлголтгүй хүний санаа бодлоор бичжээ. Тэр нь юу гэвэл, наран доорх дэлхийн хүмүүсийн санаа бодлын дагуу тэрээр бичсэн байна (Ном.үгс 1:9). Номын ихэнхэд сөрөг, мөн гутрангуй үзэл харагддаг (Ном. үгс 9:5, 10). Энэ нь амьдралыг ийм байдлаар хүлээн авахыг Их Эзэн бидэнд хүсэнийх биш, харин дэлхий дээрх гэгээрээгүй хүмүүст тохиолддог зүйлүүдийг номлогч хэрхэн ажигласан байдал юм. Номын хамгийн сүнслэг хэсэг нь, үүрдийн үнэ цэнэтэй зүйл бол Бурханы зарлигуудыг дуулгавартай дагах явдал юм хэмээн зохиогч дүгнэсэн 11, 12 дугаар бүлгүүд юм.

НОМЛОХ. Сайн мэдээ;

Номлогчийн ажлыг мөн үз

Сайн мэдээний зарчим буюу сургаалын тухай илүү сайн ойлголт өгөхийн тулд захиасаар хангах.

ЭЗЭН намайг зовогсод сайн мэдээг дэлгэрүүлэхийн тулд томилсон юм, **Иса.** 61:1 (Лук 4:16–21). Бос, Ниневеруу явж, үүнд номло, **Иона** 3:2–10.

Гэр цагаас хойш Есүс номлож эхэлжээ, **Мат.** 4:17. Бүх дэлхийгээр явж, сайн мэдээг бүх бүтээлд тунхаглагтун, **Марк** 16:15. Христ цовдлогдсоныг бид номлодог, **1 Кор.** 1:22–24. Бид явж, шорон дахь сүнснүүдэд номлосон юм, **1 Петр** 3:19. Номлож мөн Их Эзэнээс эмээх айдаст байлгахын тулд үргэлжлүүлэн бусниулахаас өөр юу ч байсангүй, **Инос** 1:23. Их Эзэнд итгэх итгэл хийгээд наманчлалаас өөр юуг ч номлох ёсгүйг тэрээр тэдэнд зарлиглав, **Моз.** 18:20. Хүмүүсээр зөвийг хийлгэхэд хөтлөхийн тулд үгийг номлох нь агуу нөлөөлөл байв, **Алма** 31:5. Дуудагдах хүртлээ номлохоор дуудагдсан хэмээн та нар ч бодох ёсгүй, **С ба Г** 11:15. Томилогдохоос бусдаар номлохоор урагш явах нь хэнд өгөгдөөгүй болой, **С ба Г** 42:11. Энэ сайн мэдээ бүх үндэстнүүдэд номлогдох ёстой, **С ба Г** 133:37. Сайн мэдээ нь эхлэлээс номлогдож эхэлжээ, **Моце** 5:58.

НОМХОН ДӨЛГӨӨН, НОМХОН ДӨЛГӨӨН БАЙДАЛ. Даруу, Даруу байдал; Тэвчээр; Харууссан зүрхийг мөн үз

Бурханаас сүрдэн эмээдэг, зөв шударга, даруу төлөв, үг сонсдог, мөн зовлон бэрхшээлтэй тулгарахад тэвчээртэй. Даруу хүмүүс сайн мэдээний сургаалуудыг дагахад бэлэн байдаг.

Моце маш даруу байлаа, **Тоол.** 12:3. Даруу хүн газар нутгийг өвлөнө, **Дуул.** 37:11 (**Мат.** 5:5; **3 Ниф.** 12:5; **С ба Г** 88:17). Дэлхийн бүхий л даруу хүмүүс ээ, та нар Эзэнийг хай, зөв шударгыг хай, төлөв байдлыг хай, **Зеф.** 2:3 (**1 Тим.** 6:11). Надаас суралц, учир нь би зүрх сэтгэлдээ дөлгөөн мөн даруу билээ, **Мат.** 11:29. Даруу байдал бол Сүнсний үр жимс мөн, **Гал.** 5:22–23. Эзэний боол бүх хүмүүст эелдэг зөөлөн, заах чадвартай, буруудахад тэвчээртэй байж, зөрөлдөгсдийг төлөв байдал дотор засаж бай, **2 Тим.** 2:24–25. Төлөв даруу хийгээд дөлгөөн тайван сүнс нь

Бурханы мэлмийд агуу их үнэтэй бөлгөө, **1 Петр** 3:4. Эгэл хүмүүнээ орхиж, даруухан бологтун, **Моз.** 3:19 (**Алма** 13:27–28). Даруу байхыг хүмүүст заа хэмээн Бурхан Хиламанд зарлиглажээ, **Алма** 37:33. Номхон тэдэнд Их Эзэний ач ивээл хангалттай, **Ифер** 12:26. Хүлцэнгүй номхон байдлын тань учир Христэд итгэх итгэл та нарт байгаа, **Моро.** 7: 39. Зүрх сэтгэлдээ номхон байхаас бусдаар хэн ч Бурханы өмнө хүлээн зөвшөөрөгдөхүйц байхгүй, **Моро.** 7:44. Нүглийн ангижрал нь даруу байдал мөн зүрх сэтгэлийн хүлцэнгүй чанарыг авчирдаг, мөн даруу байдлын улмаас Ариун Сүнсний айлчлал ирэх бөлгөө, **Моро.** 8:26. Миний Сүнсний даруу байдалд алхагтун, **С ба Г** 19:23. Гэр орноо даруу байдалд удирдан хөтөл, **С ба Г** 31:9. Санваарын хүч хийгээд нөлөө нь зөөлөн дөлгөөн бөгөөд даруу байдлаар оршин байж чадна, **С ба Г** 121:41.

НӨХӨР. Гэр бүл; Гэрлэлт, Гэрлэхийг үз

НӨХӨРЛӨЛ. Хайр; Эв нэгдлийг мөн үз

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хувьд нөхөрлөл нь бусадтай нөхөрсгөөр хамтран ажиллах, үйлчлэх, дэмжих түүнчлэн тэднийг бэхжүүлэх явдлыг багтаадаг.

Хөршөө өөрийн адил хайрла, **Лев.** 19:18 (**Мат.** 19:19; **С ба Г** 59:6). Чи хөрвүүлэгдсэнийхээ дараа ахан дүүсээ бэхжүүл, **Лук** 22:32. Хэрэв та нар бие биенээ хайрлах аваас, та нар миний шавь нар мөн, **Иохан** 13:35. Миний хонийг тэжээгтүн, **Иохан** 21:15–17. Ариун хүмүүсийн төлөөх үйлчлэлд оролцох ивээлийг бид өөрсөд дээрээ авахын тулд тэд залбирав, **2 Кор.** 8:1–5. Бидний нөхөрлөл нь Эцэг хийгээд түүний Хүүтэй нөхөрлөх нөхөрлөл юм, **1 Иохан** 1:3. Нифайчууд болон леменчүүд бие биентэйгээ нөхөрлөв, **Хил.** 6:3. Хүн болгон ах дүүгээ өөр шигээ хүндлэг, **С ба Г** 38:24–25. Хэрэв та нар нэг

бус байвал, та нар минийх биш, **С ба Г 38:27**. Би чамд найз чинь мөн ах чинь байхын тулд чамайг нөхөрлөлд хүлээн авдаг, **С ба Г 88:133**.

НУУЦ ХУЙВАЛДААНУУД.

Гадиантоны дээрэмчид;
Каиныг мөн үз

Бүлгийн хилэнцэт зорилгуудыг хэрэгжүүлэхийн тулд тангаргаар холбогдсон хүмүүсийн байгууллага.

Худал бүхний эцэг хүмүүний үрсийг нууц хуйвалдаанд өдөөн хатгадаг, **2 Ниф. 9:9**. Харанхуйн нуугдмал үйлүүдийг би устгах шаардлагатай, **2 Ниф. 10:15**. Бурханы шүүлт нууц хуйвалдааныг үйлдэгсдийн дээр ирсэн буюу, **Алма 37:30**. Гадиантон Нифайн хүмүүсийн бараг бүрэн устгалыг авчирсан билээ, **Хил. 2:4–13**. Сатан хүмүүсийн зүрх сэтгэлд нууц тангараг хийгээд гэрээний хэлбэрийг суулгав, **Хил. 6:21–31**. Их Эзэн нууц хуйвалдаанаар ажилладаггүй, **Ифер 8:19**. Нууц хуйвалдааныг дэмжих үндэстэн устгагдах болно, **Ифер 8:22–23**. Нууц нийгэмлэгийнхээ улмаас тэд бошиглогчдын бүх үгсийг эсэргүүцэв, **Ифер 11:22**. Каины өдрүүдээс хойш нууц хуйвалдаанууд байсаар ирсэн бөлгөө, **Моце 5:51**.

НҮГЛҮҮДЭЭС АНГИЖРАХ. Есүс

Христ; Өршөөх; Наманчлал,
Наманчлах; Цагаатгал,
Цагаатгах мөн үз

Буруу зүйл хийснийг наманчлалын нөхцөлд өршөөх буюу уучлах. Нүглүүдийн ангижрал нь Есүс Христийн цагаатгалаар боломжтой болдог. Хэрэв хүн Есүс Христэд итгэх итгэлтэй байж, нүглүүдээ наманчлан, баптисм хийгээд гар тавилтаар Ариун Сүнсний бэлэг хүлээн авч, мөн Бурханы зарлигуудыг дуулгавартай дагадаг бол тэрээр нүглүүдийн ангижралыг олно (ИТ 1:3–4).

Та нарын нүглүүд час улаан мэт боловч час шиг цагаан болно, **Иса. 1:16–18**. Энэ бол нүглүүдийн уучла-

лын тулд олны төлөө урсах миний цус юм, **Мат. 26:28** (Евр. 9:22–28; С ба Г 27:2). Наманчил, мөн нүглүүдийн ангижралын тул баптисм хүрт, **Үйлс 2:38** (Лук 3:3; С ба Г 107:20). Есүст итгэдэг хүмүүс нүглүүдийн ангижралыг олох болно, **Үйлс 10:43** (Моз. 3:13). Христ бол тэд нүглээс ангижрахын тулд эрж хайвал зохих тэрхүү эх сурвалж мөн, **2 Ниф. 25:26**. Нүглүүдийнхээ ангижралыг хадгалахын тулд бид ядуус болон гачигдалтай хүмүүсийг халамжлах ёстой, **Моз. 4:11–12, 26**. Наманчилдаг хэн боловч нүглүүдийнхээ ангижралын тул нигүүлсийг хүртэх эрхтэй, **Алма 12:34**. Зарлигуудыг биелүүлэх нь нүглүүдийн ангижралыг авчирдаг, **Моро. 8:25**. Аароны Санваар нь нүглүүдээс ангижрахын тулд усанд умбуулан баптисм хүртээх түлхүүрүүдийг атгадаг, **С ба Г 13:1** (С ба Г 84:64, 74; ИТ 1:4). Их Эзэн бибээр тэдний нүглүүдийг цаашид санах нь үгүй, **С ба Г 58:42–43** (Езек. 18:21–22). Нүглүүдээс ангижруулахын тулд төлөөлөн хийх баптисм хүртэхийг тэдэнд заадаг байлаа, **С ба Г 138:33**.

НҮГЭЛ. Бузар булай явдал;

Бурханлиг бус; Гомдоох; Ёс бус,
Ёс бус явдал; Жигшүүртэй,
Жигшүүрт явдал; Шударга
бус, Шударга бус явдал;
Эсэргүүцэлийг мөн үз

Бурханы зарлигуудад санаатайгаар дуулгаваргүй байх.

Гэм нүглээ нуун далдлагч хэзээ ч амжилтанд хүрэхгүй, **Сур. үгс 28:13**. Та нарын нүглүүд час улаан боловч цас шиг цагаан болно, **Иса. 1:18**. Гэм нүгэлтнүүд нас барна, мөн зөв шударгыг үйлдэгчид аврагдах болно, **Езек. 18**. Бурханы Хурга дэлхийн гэм нүглийг авсан билээ, **Иохан 1:29**. Баптисм хүртэж, өөрсдийнхөө гэм нүглийг угаацгаа, **Үйлс 22:16**. Нүглийн хөлс нь үхэл юм, **Ром. 6:23**. Зөв юмыг үйлдэхийг мэддэг хэрнээ үл үйлддэг хүнд энэ нь нүгэл юм, **Иаков 4:17**. Та намайг нүглийг хараад чичрэх нэгэн болгоно уу, **2 Ниф.**

4:31. Нүглүүддээ үхэх тэдэнд халаг, **2 Ниф.** 9:38. Тэд жигшлээс өөрөөр нүглийг үзэж эс чадна, **Алма** 13:12. Чи нүглээс аз жаргалд сэргээгдэх болно гэж бүү бод, **Алма** 41:9–10. Их Эзэн нүглийг хамгийн бага хэмжээгээр байлаа ч, зөвшөөрч чаддаггүй билээ, **Алма** 45:16 (С ба Г 1:31). Бяцхан хүүхдүүд нүгэл үйлдэх чадваргүй, **Моро.** 8:8. Наманчлахын тул хүн нүглээ хүлээн зөвшөөрч мөн орхих шаардлагатай, **С ба Г** 58:42–43. Уучилдаггүй түүнд агуу их нүгэл үйлдэг, **С ба Г** 64:9. Агуу гэрлийн эсрэг тэрээр агуу буруутгалыг хүлээн авах болно, **С ба Г** 82:3. Нүгэл үйлддэг түүнд урьдах нүгэл нь буцаж ирнэ, **С ба Г** 82:7. Бид нүглээ нуухад тэнгэр өөрийгөө татан авдаг буюу, **С ба Г** 121:37.

НҮД, МЭЛМИЙ

Судруудад мэлмий буюу нүд нь ихэвчлэн Бурханы гэрлийг хүлээж авах хүний чадварын бэлэгдэл байдаг. Бэлэгдлийн хувьд хүний нүд нь бас сүнсний нөхцөл хийгээд Бурханы зүйлүүдийг ойлгох ойлголтыг харуулдаг.

Эзэний зарлиг тодорхой, нүдийг нээж өгдөг, **Дуул.** 19:8. Мунхаг хүмүүс нүдтэй боловч хардаггүй, **Иер.** 5:21, **Марк.** 6:22, **Лук.** 11:34; **3 Ниф.** 13:22; **С ба Г** 88:67. Та нарын нүд хардаг тул нүд чинь ерөөлтэй еэ, **Мат.** 13:16. Ойлголтын нүд чинь гэгээрэх болно, **Ефес** 1:17–18. Өөрсдийн нүдэнд ухаалаг болох тэдэнд халаг, **2 Ниф.** 15:21, **Иса.** 5:21. Хүмүүсийн нүд нээгдэж болохын тулд тэд мацаг барин мөн залбирч эхлэв, **Моз.** 27:22. Сатан тэдний нүдийг сохолжээ, **3 Ниф.** 2:2. Бурханы алдар сууд нэг чигт нүдтэй байхаас бусдаар Мормоны Номыг урагш авчрах хүч хэнд ч үгүй бөлгөө, **Морм.** 8:15. Сүнсний хүчээр бидний нүд нээгдэж мөн бидний ойлголтууд гэгээрдэг, **С ба Г** 76:12. Гэрэл нь та нарын мэлмийг гэгээрүүлдэг түүгээр дамждаг, **С ба Г** 88:11. Хэрэв та нарын нүд мөнхийн алдар сууд нэг чигт байх аваас,

та нарын бүх л биес чинь гэрлээр дүүргэгдэх болно, **С ба Г** 88:67.

НЭГ. Бурхан, Бурхан тэргүүтэн;
Эв нэгдлийг үз

НЭГ ТОХОЙ

Иудейчүүдийн дундах ердийн уртын хэмжүүр—ерөнхийдөө тохойноос хурууны үзүүр хүртэлх зай.

НЭГДСЭН ЖУРАМ. Өргөл өргөх,
Өргөлийн хуулийг мөн үз

Сэргээгдсэн Сүмийн эхний үед Гэгээнтнүүдээр дамжуулан өргөлийн хуулиар амьдрахыг эрэлхийлж байсан байгууллага. Хувь хүмүүс өмч хөрөнгө, эд хогшил болон ашгаа хуваалцаж, хэрэгцээнийхээ дагуу эдгээр зүйлсийг хүлээн авдаг байв (**С ба Г** 51:3; 78:1–15; 104).

Эд материалын зүйлдээ та нар тэнцүү байх ёстой, **С ба Г** 70:14. Гэгээнтнүүд зохион байгуулагдаж мөн бүх зүйлд тэгш байх ёстой, **С ба Г** 78:3–11 (**С ба Г** 82:17–20). Их Эзэн нэгдсэн журамд илчлэлт хийгээд зарлиг өгчээ, **С ба Г** 92:1. Жон Жонсон нэгдсэн журмын гишүүн болох ёстой, **С ба Г** 96:6–9. Нэгдсэн журмыг ажиллуулах ерөнхий зааврыг Их Эзэн өгчээ, **С ба Г** 104. Миний хүмүүс селестиел хаант улсын шаарддаг холбооны дагуу нэгддэггүй байна, **С ба Г** 105:1–13.

НЯМ ГАРАГ. Хүндэтгэлийн
өдрийг үз

ОБАДИА

Едомын хувь тавиланг угтан хэлсэн Хуучин Гэрээний бошиглогч. Тэрээр Иехорамын хаанчлалын (мэө 848–844) буюу мэө 586 он дахь Вавилоны эзлэн түрэмгийллийн үед бошиглож байсан бололтой.

Обадиан ном. Хуучин Гэрээн дэх нэг ном. Энэ ном ердөө ганцхан бүлэгтэй. Үүнд, Обадиа Едомын уналтын тухай бичиж, мөн аврагчид Сион Уулан дээр зогсох болно хэмээн бошигложээ.

ОБЕД. Боаз; Рутыг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Боаз Рут хоёрын хүү түүнчлэн Хаан Давидын эцэг болсон Иессегийн эцэг (Рут 4:13–17, 21–22).

ОЙЛГОЛТ. Мэдлэг; Мэргэн ухаан;

Үнэнийг *мөн үз*

Зарим үнэн, түүний дотор үүнийг амьдралд хэрэглэх утга учрыг ойлгон хүлээн авах мэдлэгийг хуримтлуулах.

Өөрийн ойлголтод бүү түшиглэ, **Сур. үгс** 3:5. Олж авсан бүхнээрээ ухааныг ол, **Сур. үгс** 4:7. Есүсийг сургаалт зүйрлэлээр ярихад зарим нь ойлгосонгүй, **Мат.** 13:12–17. Их Эзэн тэдний оюун ухааныг нээсэн билээ, **Лук** 24:45. Хэрэв та нар эдгээрийг ойлгож эс чадах аваас, энэ нь та нар асуугаагүйн учир буюу, **2 Ниф.** 32:4 (3 Ниф. 17:3). Бид уншиж мөн ойлгож болохын тул цэдгүүд хадгалагдсан болой, **Моз.** 1:2–5. Итгэлгүйнхээ улмаас тэд Бурханы үгийг ойлгож чадсангүй, **Моз.** 26:3. Тэд зөв ойлголттой хүмүүс байв, **Алма** 17:2–3. Үг нь миний ойлголтыг өсгөж эхэлдэг, **Алма** 32:28. Та нар ойлгож болохын тулд хамтдаа хэлэлцэцгээе, **С ба Г** 50:10–12, 19–23. Эцэг эхчүүд хүүхдүүддээ ойлгохоор заах ёстой, **С ба Г** 68:25. Бурханы ажлууд хийгээд нууцууд зөвхөн Ариун Сүнсээр ойлгогдож чадна, **С ба Г** 76:114–116. Сатан хүмүүний зүрх сэтгэлийг ойл-

голтоос эргүүлэхийг эрэлхийлдэг, **С ба Г** 78:10. Христийн гэрэл бидний ойлголтыг амилуулдаг, **С ба Г** 88:11.

ОЛОН ЭХНЭР АВАХ ЁС. Гэрлэлт, Гэрлэх—Олон эхнэр авах ёсыг үз

ОМЕГА. Альфа ба Омега; Есүс Христийг үз

ОМНЕР. Бенжамины хүү, Мозая, түүний хөвгүүдийг *мөн үз*

Мормоны Номонд Хаан Мозаягийн хүү. Омнер ах нарынхаа хамт леменчүүдэд номлохоор явжээ, (**Моз.** 27:8–11, 34–37; 28:1–9).

ОМНАИ

мээ 361 оны үед бичиж байсан Мормоны Номон дахь нифайчуудын цэдэг хөтлөгч (**Жером** 1:15; **Омнаи** 1:1–3).

Омнаин ном: Нифайн бага ялтсуудаас орчуулагдсан Мормоны Номон дахь нэг ном. Уг ном нь нифайчууд болон леменчүүдийн хоорондох дайнуудын шастирыг агуулсан ганцхан бүлэгтэй. Омнаи уг номны зөвхөн эхний гурван шүлгийг бичжээ. Ялтсуудыг дараа нь Амарон, Чемиш, Абинадом мөн эцэст нь Амаликайд дараалан дамжуулж өгсөн байна. Амаликай, Зарахемлагийн хаан, Бенжамин Хаанд ялтсуудыг шилжүүлэн өгчээ.

ОН ДАРААЛЛЫН БИЧИГ

Дараах он дарааллын бичиг буюу үйл явдлуудын жагсаалт нь бүх талыг хамарсан биш бөгөөд зөвхөн Библийн болон Мормоны Номны үеийн үйл явдлуудын дарааллын талаар уншигчид ойлголт өгөх зорилготой юм:

Эртний үеийн патриархуудын үе дэх үйл явдлууд: (Энэ хэсэг дэх үйл явдлуудын яг тодорхой оныг тогтоох нь хэцүү учраас онуудыг өгөөгүй байна.)

мээ (мээ буюу—Манай эриний өмнөх үе)

4000 Адам унав.

Енох тохинуулав.

Ноа тохинуулав, дэлхий үерт автав.

Бабелын Цамхаг баригдав; Жаредчууд Амлагдсан нутаг уруу явав.

Мелкизедек тохинуулав.

Ноа нас барав.

Абрам (Абрахам) төрөв.
 Исаак төрөв.
 Иаков төрөв.
 Иосеф төрөв.
 Иосеф Египетэд худалдагдав.
 Иосеф Фараогийн өмнө гарч ирэв.
 Иаков (Израил) болон түүний гэр бүл Египет уруу явав.
 Иаков (Израил) нас барав.
 Иосеф нас барав.
 Мосе төрөв.
 Мосе Израилын хүүхдүүдийг Египетээс гаргав (Египетээс
 Гарсан нь).
 Мосе хувирав.
 Иошуа нас барав.
 Иошуаг нас барсны дараа шүүгчдийн үе эхэлж, анхны шүүгч нь
 Офниел, сүүлчийнх нь Самуел байв; бусад шүүгчдийнх нь
 дараалал болон он дараалал нь маш бүдэг юм.
 Саул хаан байхаар тослон адислагдав.

Израилын Нэгдсэн Хаант Улсын үйл явдлууд

1095 он Саулын хаанчлал эхэлжээ.
 1063 он Самуел Давидыг хаан байхаар тослон адислав.
 1055 он Давид Хеброны хаан болов.
 1047 он Давид Иерусалимын хаан болов; Натан болон Гад бошиглов.
 1015 он Соломон бүх Израилын хаан болов.
 991 он Ариун Сүм дуусав.
 975 он Соломон нас барав; Рехобоамын болон түүний хүүгийн эсрэг
 умардын арван овог бослого гаргав, мөн Израил хуваагдав.

Израилын үйл явдлууд: Иудейн үйл явдлууд:

*Мормоны Номон дахь
 үйл явдлууд:*

975 он Иеробоам Израилын хаан байв.	949 он Египетийн хаан Шишак
875 он Ахаб Израилын умард дахь Самарийг захирч байв. Елиа бошиглов.	Иерусалимыг тонон дээрэмдэв.
851 он Елиша агуу гайхамшгуудыг үйлдэв.	
792 он Амос бошиглов.	
790 он Иона, Хосеа нар бошиглов.	740 он Исаиа бошиглож эхлэв. (Ром үндэслэг- дэв; 747 онд Набона- зар Вавилоны хаан байв; 747–734 онд Тиглаф—Пилесер III Ассирийн хаан байв.)

<i>Израилын үйл явдлууд: Иудейн үйл явдлууд:</i>		<i>Мормоны Номон дахь үйл явдлууд:</i>
721 он Умард Хаант улс устгагдав; арван овог боолчлолд оров; Мика бошиглов.	728 он Хезекиа Иудейн хаан байв (4-р Шалманезер Ассирийн хаан байлаа.) 642 он Нахум бошиглов. 628 он Иеремиа Зефани нар бошиглов. 609 он Обадиа бошиглов; Даниелыг Вавилонд боолчлохоор авчрав. (608 онд Ниневе унав; 604–561 онд Небухаднезар Вавилоны хаан байв.)	600 он Лихай Иерусалимаас явав.
	598 он Вавилонд Езекиел бошиглов; Хабаккук бошиглов; Зедекиа Иудейн хаан байв.	588 он Мюлек Иерусалимаас амлагдсан нутаг уруу явав.
	587 он Небухаднезар Иерусалимыг эзлэн авав.	588 он Нифайчууд өөрсдийгөө леменчүүдээс тусгаарлав (588–570 оны хооронд).

Иудейчүүдийн түүхэн дэх үйл явдлууд:

- 537 он Иудейчүүдийг Вавилоноос буцаж явахыг Кореш зарлиглав.
520 он Хаггаи, Зехариа хоёр бошиглов.
486 он Естер амьдарч байв.
458 он Езрад шинэчлэл хийх үүрэг өгөгдөв.
444 он Нехемиа Иудейн хаанаар томилогдов.
432 он Малахи бошиглов.

Мормоны Номны түүхэн дэх үйл явдлууд:

- 400 он Жером ялтсуудыг хүлээн авав.
360 он Омнаи ялтсуудыг хүлээн авав.

- 332 он Их Александр Сири болон Египетийг эзлэн авав.
323 он Александр нас барав.
277 он Септуагинт буюу иудейчүүдийн судруудыг грек хэлэнд орчуулах ажил эхлэв.

Иудейчүүдийн түүхэн дэх үйл явдлууд:

- 167 он Маттатиа Макабее Сирийн эсрэг бослого гаргав.
 166 он Иудас Макабауе иудейчүүдийн удирдагч болов.
 165 он Ариун сүмийг цэвэршүүлж, дахин онцгойлон адислав; Ханукка үүсэн бий болов.
 161 он Иудас Макабее нас барав.

- 63 он Помпей Иерусалимыг эзэлж мөн Макабеегийн засаглал Израилд төгсгөл болов.
 51 он Клеопатра хаанчлав.
 41 он Херод, Фасаел хоёр Иудейн дөрөвний нэгийг хамтран захирах болгогдов.
 37 он Херод Иерусалимын удирдагч болов.
 31 он Актиумын тулалдаан болов;
 мэ 31 оноос мэ 14 он хүртэл Август Ромын эзэн хаан байв.
 30 он Клеопатра нас барав.
 17 он Херод ариун сүмийг сэргээв.

Мормоны Номны түүхэн дэх үйл явдлууд:

- 148 он Абинадай алагдав; Алма нифайчуудын дунд Сүмийг дахин байгуулав.
 124 он Бенжамин сүүлчийнхээ үгийг нифайчуудад хэлэв.
 100 он Залуу Алма болон Мозаягийн хөвгүүд ажлаа эхлэв.
 91 он Шүүгчдийн засаглал нифайчуудын дунд эхлэв.

- 5 он Лемен үндэстэн Самуел Христийн төрөлтийн тухай бошиглов.

Христийнхний түүхэн дэх үйл явдлууд:

- мэ (Манай эриний үе)
 Есүс Христийн төрөлт
 30 он Христийн тохинуулал эхлэв.
 33 Христ цовдлогдов.
 35 он Паул хөрвүүлэгдэв.
 45 он Паул анхныхаа номлолын аяллыг хийв.
 58 он Паулыг Ром уруу илгээв.
 61 он Төлөөлөгчдийн Үйлсийн түүх хаагдав.

Мормоны Номын Түүхэн дэх үйл явдлууд:

- мэ
 33 буюу
 34 он Амилсан Христ Америкт хүрч ирэв.

Христийнхний түүхэн дэх үйл явдлууд:

- 62 он Ром шатав; Неро Христийнхнийг мөрдөн хавчив.
- 70 он Христийнхэн Пелла уруу явав. Иерусалим бүслэгдэж мөн эзлэгдэв.
- 95 он Домит Христийнхнийг хавчин гадуурхав.

Мормоны Номын Түүхэн дэх үйл явдлууд:

- 385 он Нифай үндэстэн устгагдав.
- 421 он Мороднай ялтсуудыг нуув.

ОНГОН. Мариа, Есүсийн эхийг мөн үз

Бэлгийн харьцаанд ороогүй гэрлэх насны эрэгтэй буюу эмэгтэй хүн. Судруудад, онгон нь ёс суртахуунаар цэвэр ариун хүнийг төлөөлдөг (Илч. 14:4).

Онгон бүсгүй хүүхэдтэй болж хүү төрүүлнэ, **Иса.** 7:14 (Мат. 1:23; 2 Ниф. 17:14). Тэнгэрийн хаант улс нь арван онгон охинтой адил юм, **Мат.** 25:1–13. Назар хотод Бурханы Хүүгийн эх болох онгон охиныг болгоов, **1 Ниф.** 11:13–18. Мариа нь онгон, хонгорхон, сонгомол сав байв, **Алма** 7:10.

ОНГОН МАРИА. Есүсийн эх Мариаг үз

ОНЦГОЙЛОН АДИСЛАХ. Гар тавих; Дуудлага, Дуудахыг мөн үз

Ариун зорилгуудын төлөө сонгогдох хийгээд ариулагдан адислагдах. Энэ томилолт нь зохих эрх мэдэлтэй нэгэн гар тавьснаар Сүмийн байгууллага дахь онцгой үйлчлэлд зориулагддаг. Зөвхөн санваартны чуулгуудыг тэргүүлдэг хүмүүс онцгойлон адислагдах үедээ түлхүүрүүдийг хүлээн авдаг. Санваартны чуулгуудын ерөнхийлогчөөс бусад албан тушаалуудад онцгойлон адислагдах үедээ хүмүүс санваарын адислалыг хүлээн авдаг боловч уг адислалд түлхүүрүүдийг өгдөггүй.

Ажлын тул намайг Барнаб, Саул хоёроос салга, **Үйлс** 13:2–3. Бусад бишо-

пууд онцгойлон адислагдана, **С ба Г** 68:14. Бишоп бол нийтийн шүүгч, энэ тохинуулалд онцгойлон адислагдах болно, **С ба Г** 107:17, 74. Хүн Бурханаас бошиглоолоор мөн гар тавилтаар дуудагдах ёстой, **ИТ** 1:5.

ОРЧУУЛАХ

Нэг хэлэн дээр өгсөн санааг адилхнаар нөгөө хэлээр илэрхийлэх (Моз. 8:8–13; ИТ 1:8). Судруудад үүнийг ихэнхдээ Бурханы бэлэг хэмээн хэлдэг (Алма 9:21; С ба Г 8; 9:7–9). Энэ нь заримдаа хэлэнд нэгэнт байгааг орчуулан сайжруулах буюу засварлах, эсвээс алдагдсан сэдвийг дахин сэргээх гэсэн утгатай байдаг (С ба Г 45:60–61). Хаан Жеймсийн Библийн сүнсээр өдөөгдсөн орчуулгыг хийхээр Иосеф Смит зарлигдуулсан байлаа (С ба Г 42:56; 76:15).

Бурханы нигүүлсэл, Бурханы хүчээр дамжуулан орчуулах хүч Иосеф Смитэд байв, **С ба Г** 1:29. Чамд орчуулах бэлэг буй, **С ба Г** 5:4. Хэрэв чи надаас хүсэх аваас би чамд орчуулах бэлэг өгөх болно, **С ба Г** 6:25. Бурхан Иосеф Смитэд Мормоны Номыг орчуулах хүчийг дээрээс өгсөн ажгуу, **С ба Г** 20:8. Урим ба Туммимыг ашиглан би заримыг нь орчуулсан бөлгөө, **ИС—Т** 1:62 (Моз. 8:13; 28:13).

ОЮУН БИЛИГ, ОЮУН

БИЛГҮҮД. Гэрэл, Христийн гэрэл; Сүнс; Үнэнийг мөн үз

Оюун билиг нь нилээд хэдэн утгатайгаас гурвыг нь энд авч үзвэл:

(1) Энэ нь ертөнц дэх бүх зүйлүүдэд амьдрал хийгээд гэрлийг өгдөг үнэний гэрэл юм. Энэ нь байнга оршдог. (2) *Оюун билиг* гэдэг үг нь түүнчлэн Бурханы хүүхдүүдийн сүнсийг заадаг. (3) Мөн түүнчлэн биднийг сүнсэн хүүхдүүд болж төрөөс өмнө оюун билиг нь сүнслэг биет байдлаар оршиж байсан тухай судрууд өгүүлдэг.

Оюун билиг оюун билигтэй нэгдэн нийлдэг, **С ба Г** 88:40. Оюун билиг бүтээгдсэн буюу хийгдсэн нь үгүй, **С ба Г** 93:29. Бүх оюун билиг нь Бурхан үүнийг байрлуулсан тэрхүү хүрээнд бие даасан байдалтай байдаг, **С ба Г** 93:30. Бурханы алдар суу бол оюун билиг юм, **С ба Г** 93:36–37. Энэ амьдралд олдсон оюун билиг амиуултад бидэнтэй хамт сэргэх болно, **С ба Г** 130:18–19. Их Эзэн бүх оюун билгийг захирдаг, **Абр.** 3:21. Дэлхий байхаас өмнө зохион байгуулагдсан оюун билгүүдийг Их Эзэн Абрахамд үзүүлжээ, **Абр.** 3:22.

ОЮУН УХААН, ОЮУН САНАА

Оюуны чадвар; тунгаан бодох ухамсрын хүч.

Бүх зүрх болон оюун ухаанаараа Түүнд үйлчлэгтүн, **Шаст.** дээд 28:9. Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла. **Мат.** 22:37. Биеэ бодсон байх нь үхэл; сүнсээ бодсон байх нь мөнхийн амьдрал, **2 Ниф.** 9:39. Намайг оюун бодолдоо байхад Их Эзэний дуу хоолой ирэв, **Инос** 1:10. Үг нь хүмүүсийн оюун ухаанд илднээс илүү хүчтэй нөлөө үзүүлсэн байв, **Алма** 31:5. Би чамд оюун ухаанд чинь хэлэх болно, **С ба Г** 8:2. Үүнийг оюун ухаандаа сурч ав, **С ба Г** 9:8. Үүрд мөнхийн чанд зүйлүүд оюун ухаан дээр тань амраг, **С ба Г** 43:34. Өнгөрсөн үеүдэд та нарын оюун ухаан харласан буюу, **С ба Г** 84:54. Та нарын бие болоод оюун ухаан тань тунгалаг байхын тулд эрт унтаж, эрт босч бай, **С ба Г** 88:124. Бурханы оюун ухааныг Сатан мэддэггүй байв,

Моисе 4:6. Тэд нэг зүрх сэтгэл, мөн нэг оюун ухаантай байсан учраас Их Эзэн өөрийн хүмүүсийг Сион хэмээн нэрлэжээ, **Моисе** 7:18.

ӨВ ЗАЛГАМЖЛАГЧ

Биет болоод сүнсний бэлгүүдийг өвлөх нэрлэгдсэн хүн. Зөв шударга хүмүүс Бурханд байдаг бүх зүйлийн өвлөгчид байхаар судруудад амлагдсан байдаг.

Абрахам өв залгамжлагчийг хүсэв, **Эхл.** 15:2–5. Абрахам итгэлийн зөвт байдлаар дамжин дэлхийн өв залгамжлагч болов, **Ром** 4:13. Бид Бурханы хүүхдүүд, хэрэв бид хүүхдүүд нь юм бол, өв залгамжлагчид, Христийн хамт Бурханы өв залгамжлагчид билээ, **Ром** 8:16–17 (С ба Г 84:38). Чи хүү нь, Христээр дамжин Бурханы өв залгамжлагч билээ, **Гал.** 4:7. Бурхан Хүүгээ бүх зүйлийн өв залгамжлагчаар томилжээ, **Евр.** 1:2. Нүглүүдийнхээ ангижралын төлөө харуулдан хүлээдэг тэд Бурханы хаант улсыг өвлөгчид болой, **Моз.** 15:11. Хүмүүс Христийн хүүхдүүд, мөн Бурханы хаант улсын өв залгамжлагчид болов, **4 Ниф.** 1:17. Сайн мэдээний тухай мэдлэггүйгээр нас барсан тэд селестиел хаант улсын өв залгамжлагчид болж болно, **С ба Г** 137:7–8. Наманчилдаг нас барагсад авралын өв залгамжлагчид мөн, **С ба Г** 138:59. Абрахам зөв шударга байдлаараа эрх бүхий өв залгамжлагч байв, **Абр.** 1:2.

ӨВ ЗАЛГАМЖЛАХ ЭРХ. Гэрээ;

Ууганыг мөн үз

Өв хөрөнгө ууган хүүд залгамжлагдах эрх. Өргөн утгаараа бол, өв залгамжлах эрх нь аль нэг буюу бүх эрх, эсвээс өв нь гэр бүл хийгээд улс оронд хүн төрөхөд түүнд шилжих явдлыг өөртөө багтаадаг.

Ууган хүү байх эрхээ өнөөдөр надад худалдаач, **Эхл.** 25:29–34 (Эхл 27:36). Ууган нь өөрийнхөө ууган хүү байх эрхийн дагуу суужээ, **Эхл.** 43:33. Тэрээр Манассегаас Ефраимыг дээгүүр

тавьжээ, **Эхл.** 48:14–20 (Иер. 31:9). Ууган хүү байх эрх нь Иосефынх, **Шаст.** дээд 5:2. Есав өөрийнхөө ууган хүү байх эрхээ зарсан, **Евр.** 12:16. Та нар бол хууль ёсны өв залгамжлагчид, **С ба Г** 86:9. Сион удам угсаагаараа санваарын эрх мэдэлтэй байдаг, **С ба Г** 113:8 (Абр 2:9–11).

ӨВЧТӨНИЙГ АДИСЛАХ. Гар Тавих; Тос; Тослох; Санваар; Эдгээлт, Эдгээхийг *мөн үз*

Мелкизедек санваар атгадаг эрэгтэйчүүд ариулсан тос ашиглан өвчтөнүүдэд өгдөг адислал.

Охины толгой дээр гараа тавь, **Мат.** 9:18. Есүс өвчтэй байсан хэдэн хүн дээр гараа тавьж эдгээжээ, **Марк** 6:5. Христийн Төлөөлөгчид олон өвчтэй хүнийг тосоор тослон эдгээжээ, **Марк** 6:13. Ахлагч нар тосолж мөн өвчтөнийг эдгээх ёстой, **Иаков** 5:14–15. Та нараас үүнийг хүсэгч тэднээр шаардахаас бусдаар та нар өвчтэйг эдгээх ёсгүй, **С ба Г** 24:13–14. Ахлагч нар өвчтөний дээр гар тавих ёстой **С ба Г** 42:44. Гараа өвчтөний дээр тавь, мөн тэд эдгэрэх болно, **С ба Г** 66:9.

ӨВЧТЭЙ, ӨВЧИН

Өвчин буюу эмгэг хуучтай байх. Судруудад биеийн өвчин нь заримдаа сүнслэг сайн сайхан байдал дутагдахын бэлэгдэл болдог (Иса. 1:4–7; 33:24).

Би чиний залбирлыг сонслоо, би чиний нулимсыг үзлээ; болгоогтун, би чамайг эдгээх болно, **Хаад.** дэд 20:1–5 (Шаст. дэд 32:24; Иса. 38:1–5). Есүс явж янз бүрийн өвчин эмгэгийг эдгээв, **Мат.** 4:23–24 (1 Ниф. 11:31; Моз. 3:5–6). Эмч эрүүл хүмүүст бус, өвчтэй хүмүүст хэрэгтэй, **Мат.** 9:10–13 (Марк 2:14–17; Лук 5:27–32). Та нарын дунд өвчтэй хүн байна уу? Тэрээр ахлагч нарыг дуудаг, **Иаков** 5:14–15. Христ өөр дээрээ өөрийн хүмүүсийн шаналал мөн өвчнүүдийг авах болно, **Алма** 7:10–12. Нифайчуудын дундах өвчтэй бүх

хүмүүсийг Христ эдгээв, **3 Ниф.** 26:15. Өвчтөнийг нинжин сэтгэлээр, ургамлаар мөн зөөлөн хоолоор асар, **С ба Г** 42:43 (Алма 46:40). Бүх зүйл дээр өвчтэй хийгээд зовж зүдэрснийг сана, **С ба Г** 52:40. Гараа өвчтөний дээр тавь, тэд эдгэрэх болно, **С ба Г** 66:9.

ӨГЛӨГ, ӨГЛӨГ ӨГӨХ. Мацаг, Мацаг барих; Өргөл; Халамж, Ядуусыг *мөн үз*

Ядууст туслах өргөлүүд.

Өглөгүүд чинь хүмүүсийн өмнө бүү байг, **Мат.** 6:1–4 (3 Ниф. 13:1–4). Энэ ядуу бэлэвсэн эмэгтэй бүх хүмүүсээс илүүг өглөө, **Марк** 12:41–44. Авахаас өгөх нь илүү адислагддаг, **Үйлс** 20:33–35. Та нарыг ядуустай хөрөнгөө хуваалцаасай гэж хүсч байна, **Моз.** 4:26. Сүмийн хүмүүс хөрөнгөө хүн бүр өөрт байгаагийнхаа хэрээр хуваалцах ёстой, **Моз.** 18:27.

ӨМГӨӨЛӨГЧ. Есүс Христийг *мөн үз*

Есүс Христ бол Эцэгийн өмнө бидний өмгөөлөгч (Моро. 7:28) билээ, мөн бидний төлөө түүний өмнө өмгөөлдөг.

Есүс Христ бол Эцэгт бидний өмгөөлөгч билээ, **1 Иох.** 2:1 (С ба Г 110:4). Есүс бүгдийн өмгөөлөгч болно, **2 Ниф.** 2:9 (Евр 7:25). Есүс үхлийг даван ялалтыг олж, хүмүүний үрсийн тул өмгөөлөх хүчийг өөртөө өгсөн, **Моз.** 15:8. Бибээр Эцэгийн өмнө та нарын өмгөөлөгч болой, **С ба Г** 29:5. Есүс Христ та нарын улмаас гуйх болно, **С ба Г** 45:3–5.

ӨР. Өршөөхийг *мөн үз*

Судруудад хэрэглэгдсэнээр, мөнгө болон эд зүйлээр бусдад өртэй байх нь зээлдэгчийг боолчлолын хэлбэрт байлгахад хүргэдэг. Нөгөө талаар, бидний эсрэг гэм үйлдсэнийх нь төлөө бусдыг уучилсны дараа, Есүс Христийн цагаатгалаар дамжуулан өөрсдийн өрийг өршөөхийг, эсвээс

нүглүүдийнхээ төлөөсийг төлөхөөс чөлөөлөхийг бид Эцэгээс гуйх ёстойг Есүс заадаг байлаа (Мат. 6:12; 3 Ниф. 13:11).

Хилэнцтэн зээлж, буцаан өгдөггүй, **Дуул.** 37:21. Өртөн нь зээлдүүлэгчийн зарц юм, **Сур.** үгс 22:7. Би чиний бүх өрийг хэлтрүүлсэн: чамд өрөвч сэтгэл байх ёстой биш гэж үү? **Мат.** 18:23–25. Нэг нэгэндээ хайртай байхаас өөр хэнд ч ямар ч өргүй бай, **Ром** 13:8. Та нар Тэнгэрлэг Эцэгтээ мөнхийн өрөнд орсон, **Моз.** 2:21–24, 34. Хөршөөсөө зээлсэн хэн боловч зээлсэн тэр зүйлээ эргүүлж өгөх ёстой, **Моз.** 4:28. Өрөө төл, мөн өөрсдийгөө боолчлолоос чөлөөл, **С ба Г** 19:35. Өөрсдийнхөө дайсанд өртэй байх нь хориглогдсон билээ, **С ба Г** 64:27. Бүх өрөө төл, **С ба Г** 104:78. Их Эзэний өргөөг босгохдоо өрөнд бүү ор, **С ба Г** 115:13.

ӨРГӨЛ. Аравны нэг, Аравны нэгийг төлөх; Золиослол; Мацаг барилт, Мацаг барих; Өглөг, Өглөг өгөх; Халамжийг *мөн үз*

Их Эзэнд өргөдөг бэлэг. Хуучин Гэрээнд золиослол болон шагаалт өргөлүүд гэсэн үгийг олонтаа хэрэглэсэн байдаг. Өнөөдөр Сүм мацгийн өргөлүүд хийгээд сайн дурын бусад өргөлүүдийг (түүний дотор цаг хугацаа, авьяас билиг, тэрчлэн өмч хөрөнгө) ядууст туслах болон бусад зохистой зорлигуудын тулд хэрэглэдэг.

Та нар намайг аравны нэг ба өргөлөөр луйвардаж байна, **Малах.** 3:8–10. Эхлээд ах дүүтэйгээ эвлэр, дараа нь өргөлөө өргө, **Мат.** 5:23–24. Өөрийн бүхэл бодгалийг Христэд өргөл болгон өргөгтүн, **Омнаи** 1:26. Хэрэв хүн өргөлийг үнэн сэтгэлээсээ өргөхгүй бол, энэ нь түүнд ямар ч ашиггүй байх болно, **Моро.** 7:6. Санваарын түлхүүрүүд нь Левийн хөвгүүд Их Эзэнд зөв шударга байдалд дахин өргөл өргөх хүртэл дэлхийгээс дахин хэзээ ч авагдахгүй

байх болно, **С ба Г** 13:1. Энэхүү Их Эзэний өдөр, чи өргөлүүдээ мөн ариун ёслолуудаа Бүхний Дээдэд зориулах ёстой, **С ба Г** 59:12. Бид сүм болон хүмүүсийн хувьд Их Эзэнд зөв шударга байдалд өргөл өргөцгөө, **С ба Г** 128:24.

ӨРГӨМЖЛӨЛ. Мөнх амьдрал; Селестиел алдар суу; Титэм; Хүмүүн, Тэнгэрлэг Эцэгтэй адилхан болох боломж; Хүн; Цагаатгал, Цагаатгахыг *мөн үз*

Селестиел хаант улс дахь аз жаргал хийгээд алдар суугийн хамгийн дээд зэрэглэ.

Таны өмнө л баяр хөөр дүүрэн байдаг, **Дуул.** 16:11. Тэд бас бурхад, бүр Бурханы хүүхдүүд юм иймийн тул бүх зүйлүүд өв залгамжлагчид билээ, **С ба Г** 76:58–59. Гэгээнтнүүд өөрсдийн өвийг хүлээн авч мөн түүнтэй адил тэгш болгогдох болно, **С ба Г** 88:107. Эдгээр тэнгэр элчүүд миний хуулийг баримталдаггүй байв; тиймийн тул, тэд өргөмжлөлгүйгээр тусдаа, мөн ганц биесээрээ үлддэг, **С ба Г** 132:17. Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд өргөмжлөлийг хүртэхийн тулд Бурханы хуулийн дагуу гэрлэх ёстой, **С ба Г** 132:19–20. Өргөмжлөл уруу хөтөлдөг үүд нь шулуун бөгөөд зам нь нарийн юм, **С ба Г** 132:22:23. Абрахам, Исаак, мөн Иаков өөрсдийн өргөмжлөлд орсон билээ, **С ба Г** 132:29, 37. Би өргөмжлөлийг та нар дээр лацаддаг, **С ба Г** 132:49.

ӨРӨВЧ СЭТГЭЛ. Нигүүлсэл, Нигүүлсэнгүй; Хайр; Энэрлийг *мөн үз*

Судруудад өрөвч сэтгэл гэдэг нь шууд утгаараа “зовох” гэсэн утгатай. Энэ нь түүнчлэн талархал, харуусал хийгээд нигүүлслийг хэн нэгэнд үзүүлэх гэсэн утгатай.

Их Эзэн өөрийн хүмүүстээ өрөвдөх сэтгэлийг үзүүл хэмээн айлдсан, **Зех.** 7:8–10. Есүст өрөвөх сэтгэл төрөв,

Мат. 9:36 (**Мат.** 20:34; **Марк** 1:41; **Лук** 7:13). Нэгэн Самари хүн түүнийг өрөвдсөн, **Лук** 10:33. Бие биеэндээ энэрэнгүй бай, **1 Петр** 3:8. Христ хүмүүний үрсэд хандсан өрөвдөх сэтгэлээр дүүргэгдэв, **Моз.** 15:9. Зүрх минь та нарт хандсан өрөвдөх сэтгэлээр дүүрэв, **3 Ниф.** 17:6. Иосеф Смит Их Эзэний өрөвч сэтгэлийн төлөө залбирав, **С ба Г** 121:3–5.

ӨРШӨӨХ, УУЧЛАХ. Наманчлал, Наманчлах, Нүглүүдээс ангижрах; Хүлээн зөвшөөрөлт, Хүлээн зөвшөөрөх; Цагаатгал, Цагаатгахыг *мөн* үз

Өршөөх, уучлах гэдэг нь судруудад ерөнхийдөө хоёр утгын аль нэгээр хэрэглэгддэг: (1) Бурхан хүмүүсийг өршөөхдөө нүглийн төлөө шаардагдах цээрлэлийг үл хэрэглэх буюу хойш тавдаг. Христийн цагаатгалаар дамжсан нүглүүдийн өршөөлийг аллагад гэм буруутай буюу Ариун Сүнсний эсрэг уучилж болшгүй гэм нүгэлтэйгээс бусад наманчилдаг бүх хүмүүс хүртэх боломжтой юм. (2) Хүмүүс бие биенээ уучлахдаа, тэд Христийнх шиг хайраар бие биендээ хандаж, өөрсдийг нь гомдоосон хүмүүст муу юм санадаггүй (**Мат.** 5:43–45; 6:12–15; **Лук** 17:3–4; **1 Ниф.** 7:19–21).

Эзэн бол уурлахдаа удаан, хайр энэрлээр элбэг, гэм нүгэл, хууль бусыг уучилдаг, **Тоол.** 14:18. Та нарын нүглүүд час улаан мэт боловч, цас шиг цагаан болно, **Иса.** 1:18. Бид өртөнгүүдээ уучилсны нэг адил бидний өрийг уучлаач, **Мат.** 6:12 (**Лук** 11:4; **3 Ниф.** 13:11). Хүний Хүү нүглүүдийг уучлах хүчтэй, **Мат.** 9:6 (**Мат.** 18:35; **Марк** 2:10; **Лук** 5:20–24). Ах дүү минь миний эсрэг нүгэл үйлдэхэд би хэдэн удаа түүнийг уучлах вэ? **Мат.** 18:21–22 (**С ба Г** 98:40). Ариун Сүнсийг доромжлогч тэрээр хэзээ ч уучлагдахгүй, **Марк** 3:29 (**Алма** 39:6). Хэрэв ах дүү чинь чиний эсрэг нүгэл үйлдээд, наманчилбал, түүнийг уучил, **Лук** 17:3. Ааваа, тэднийг уучлаач, учир нь тэд

юу хийж байгаагаа мэдэхгүй байна, **Лук** 23:34. Өршөөлийн тул залбир, **1 Ниф.** 7:21. Бид нүглүүддээ өршөөлийг хүлээн авч болохын тулд Христийн цагаатгагч цусыг нөлөөлүүлээч, **Моз.** 4:2. Хэрэв тэрээр миний өмнө мөн та нарын өмнө нүглүүддээ гэмшиж, мөн наманчлах аваас та нар түүнийг өршөөх болно, **Моз.** 26:29–31. Наманчилдаг мөн зарлигуудыг биелүүлдэг тэрээр өршөөгдөх болно, **С ба Г** 1:32. Хадуураараа цохигтун, мөн нүглүүд чинь өршөөгдсөн болой, **С ба Г** 31:5 (**С ба Г** 84:61). Нүглүүдээ наманчилсан тэрээр өршөөгддөг болой, мөн Их Эзэн бибээр нүглүүдийг цаашид санах нь үгүй, **С ба Г** 58:42. Би өршөөхийгөө өршөөнө, харин бүх хүмүүсийг уучлах нь та нараас шаардагдана, **С ба Г** 64:10. Та нар бие биенийхээ гэм бурууг уучлахын хэрээр, бүр түүнчлэн Их Эзэн би та нарыг өршөөнө, **С ба Г** 82:1. Та нарын нүглүүд өршөөгдөхийн тулд би өөрөө хайрладаг та нарыг тэрчлэн шүүмжилдэг, **С ба Г** 95:1. Чиний зөрчлийг чамд өршөөсөн билээ би, **Мосе** 6:53.

ӨС ХОНЗОН. Дайсагналыг *мөн* үз

Хохироосон буюу гомдоосны улмаас өшөө авах буюу хариу авах.

Чиний Бурхан өс хонзонтойгоор ирэх болно, **Иса.** 35:4. Өс хонзон нь минийх; би буцаан төлөх болно, **Ром.** 12:19 (**Морм.** 3:15; 8:20). Өс хонзонгийн илд чиний дээр өлгөөстэй байна, **Морм.** 8:40–41. Ёс бусчуудын дээр өс хонзонг тохиолгох болой, учир нь тэд наманчлах нь үгүй авай, **С ба Г** 29:17. Аврагч ёс бус хийгээд өс хонзонгийн өдөр ирнэ, **Мосе** 7:45–46.

ПАРТРИЖ ЭДВАРД

Сүм орчин үед сэргээгдсэний дараах анхны нэг гишүүн болон удирдагч. Эдвард Партриж Сүмийн анхны бишпоор үйлчилж байв (**С ба Г** 36; 41:9–11; 42:10; 51:1–18; 115; 124:19).

ПАТРИАРХ, ПАТРИАРХЫН.

Евангелист; Мелкизедек
Санваар; Мөнх бус эцэг;
Патриархын адислалуудыг
мөн үз

Судрууд хоёр төрлийн патриархын тухай өгүүлсэн байдаг: (1) Мелкизедек санваарт томилогдсон албан тушаал, заримдаа үүнийг евангелист гэдэг, (2) гэр бүлүүдийн эцгүүд юм. Томилогдсон патриархууд Сүмийн зохистой гишүүдэд тусгай адислалуудыг өгдөг.

Томилогдсон патриархууд: Тэр заримыг нь эш үзүүлэгч, заримыг нь сайн мэдээг тунхаглагч болгожээ, **Еф.** 4:11 (ИТ 1:6). Евангелийн тохиуулагчдыг томилох нь Арванхоёрын үүрэг мөн, **С ба Г** 107:39. Хайрум санваартны хийгээд патриархын албан тушаалыг авч болно, **С ба Г** 124:91–92, 124, 135:1.

Эцгүүд: Иаков өөрийн хөвгүүд болон тэдний үр удмыг адисалжээ, **Эхл.** 49:11–28. Патриарх Давидын талаар би та нарт чөлөөтэйгээр хэлье, **Үйлс** 2:29. Лихай өөрийн үр удамд зөвлөж мөн адислав, **2 Ниф.** 4:3–11. Эцгүүдэд хамаардаг эрхийг би атган, зөв шударга өвлөгч болсон билээ, **Абр.** 1:2–4.

ПАТРИАРХЫН АДИСЛАЛУУД.

Евангелист; Мөнх бус эцэг;
Патриарх, Патриархыг *мөн үз*

Сүмийн зохистой гишүүдэд томилогдсон патриархуудаас өгдөг адислалууд. Патриархын адислал нь уг адислалыг хүлээн авч байгаа хүнд түүний израэлын угсааны гарлыг нь хэлж өгөн мөн Их Эзэний зөвлөгөөг агуулсан байдаг. Эцгүүд гэр бүлийнхээ патриархуудын хувьд онцгой адислал өгч болно, гэвч ийм адислалууд бүртгэлд орж Сүмд хадгалагддаггүй.

Израил баруун гараа сунгаж Ефраимын толгой дээр тавив, **Эхл.** 48:14. Иаков өөрийн хөвгүүд болон тэдний үр удмыг ерөөв, **Эхл.** 49. Лихай өөрийн үр удмыг адислав, **2 Ниф.** 4:3–11

ПАТТЕН, ДАВИД В.

Хожмын эрин үед сонгогдсон, анхны Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын нэг гишүүн. Давид Паттен бол 1838 онд Миссурийн Крукед гол дээр болсон тулалдаанд алагдсан, сэргээгдсэн Сүмийн анхны амь хохирогч юм.

Ажил хэргээ шийдвэрлэж, мөн номлол гүйцэтгэхээр дуудагдав, **С ба Г** 114:1. Их Эзэнд аваачигдав, **С ба Г** 124:19, 130.

ПАУЛ. Паулын захидлуудыг

мөн үз

Шинэ Гэрээн дэх Төлөөлөгч. Паулын еврей нэр нь Саул байсан бөгөөд мөн тэрбээр энэ нэрээр харийнханд хийх номлолоо эхлэх хүртэл явжээ. Тэрээр өмнө нь Сүмийг мөрдөн хавчиж байсан хэдий ч, Есүс Христийн тухай үзэгдлийг үзсэний дараа үүний үнэнд хөрвүүлэгдсэн байлаа. Паул номлолын гурван үндсэн гол аялалд явж мөн олон захидлыг Гэгээнтнүүдэд бичжээ. Эдгээр захидлуудаас арван дөрөв нь өнөөдөр Шинэ Гэрээний нэг хэсгийг бүрдүүлдэг. Эцэст нь тэрээр хоригдол болж Ромд аваачигдан, мэ 65 оны хавар алагдсан бололтой.

Стефаныг чулуудахыг хүлээн зөвшөөрсөн, **Үйлс** 7:57–8:1. Гэгээнтнүүдийг мөрдөн хавчив, **Үйлс** 8:3. Дамаскаас явж байхад нь Есүс түүнд үзэгдэв, **Үйлс** 9:1–9. Ананиагаар баптисм хүртэв, **Үйлс** 9:10–18. Арибад амарсныхаа дараа номлохоор Дамаск уруу эргэж явав, **Үйлс** 9:19–25 (Гал. 1:17). Хөрвөгдсөнөөсөө хойш гурван жилийн дараа Иерусалим уруу буцаж явжээ, **Үйлс** 9:26–30 (Гал. 1:18–19). Ромын эзэнт гүрний янз бүрийн хэсгүүдэд Сүмийн салбаруудыг зохион байгуулж мөн сайн мэдээг номлох номлогчийн гурван аялалд явжээ, **Үйлс** 13:1–14:26; 15:36–18:22; 18:23–21:15. Гурав дахь номлолынхоо дараа Иерусалимд хүрч ирээд баригдаж Кайсарид хүргэгджээ, **Үйлс** 21:7–23:35. Хоёр

жил Кайсарид хоригдож байв, Үйлс 24:1–26:32. Алагдахаар Ром уруу илгээгдэж, замдаа хөлөг онгоц нь сүйрэх зовлонг амсчээ, Үйлс 27:1–28:11.

ПАУЛЫН ЗАХИДЛУУД. Паул, захидал тус бүрийн нэрийг мөн үз

Сүмийн гишүүдэд Төлөөлөгч Паулын анх бичсэн захидлууд болох Шинэ Гэрээн дэх арван дөрвөн ном. Эдгээрийг дараах хоёр бүлэгт хувааж болно:

1 ба 2 Тесалоник (мэ 50–51 он)

Паул номлолынхоо хоёр дахь аяллын үед Коринтоос тесалончуудад уг захидлуудыг бичжээ. Тесалоникт хийсэн түүний ажил Үйлс 17-д дүрслэгджээ. Тэрээр Тесалоник уруу буцаж очихыг хүсдэг байсан хэдий ч ингэх боломж түүнд байсангүй (1 Тес. 2:18). Тиймээс хөрвөгдөгсдийг хөгжөөж, тэд ямархуу байгаа талаар өөрт нь үг авчрахын тулд тэрээр Тимотыг илгээжээ. Эхний захидал нь Тимотыг эргэж ирсэнд тэрээр баяр талархлаа дүүрэн байсны үр дүн бөлгөө. Хоёр дахь захидал нь ялигүй хожуухан бичигджээ.

1 ба 2 Коринт, Галат, Ром (мэ 55–57 он)

Асуултуудад хариулах болон Коринт дахь Гэгээнтнүүдийн дундах дэг журамгүй байдлыг залруулахын тулд Паул номлолынхоо гурав дахь аяллын үеэр уг захидлыг Коринтчуудад бичжээ.

Галатчуудад бичсэн захидал нь Галат даяар байсан Сүмийн олон нэгжүүдэд хандан бичигдсэн байлаа. Сүмийн зарим гишүүд сайн мэдээг Иудейн хуульд ашигтайгаар хэлбийлгэж байв. Энэ захидалд Паул Мосегийн хуулийн зорилго хийгээд сүнслэг шашны үнэ цэнийг тайлбарлажээ.

Ромын Гэгээнтнүүдэд айлчлан очихоор түүний найдаж байсан айлчлалд тэднийг зарим талаар бэлтгэхийн тулд Паул Коринтоос уг захидлыг Ромчуудад бичжээ. Энэ захидал нь түүнчлэн Христийн

шүтлэгт хөрвүүлэгдсэн зарим Иудейчүүдийн маргаж байсан номлолуудыг дахин нотолсон байна.

Филипптой, Колосай, Ефес, Филемон, Еврей (мэ 60–62 он)

Паул эдгээр захидлуудыг эхний удаа Ромд шоронд байхдаа бичжээ.

Филиппчүүдэд хайр талархлаа илэрхийлэх түүнчлэн тэрээр удаан хугацаагаар шоронд хоригдсоноос үүдэн бий болсон гутралаас тэднийг урамшуулан дэмжихийн тулд Паул голчлон уг захидлыг филиппчүүдэд бичжээ.

Колоссайн Гэгээнтнүүд ноцтой алдаа завхралд орсон тухай мэдээллийн үр дүн болгон уг захидлыг Паул колоссайчуудад бичжээ. Төгөлдөржилт нь Христийнх шиг зан чанарыг төлөвшүүлэхээс илүүгээр гадна талын ёслолуудыг нягт нямбай сахиснаар ирнэ гэдэгт тэд итгэдэг байжээ.

Ефесчүүдэд бичсэн захидал туйлын чухал ач холбогдолтой юм, учир нь энэ нь Христийн Сүмийн тухай Паулын заадаг зүйлүүдийг агуулдаг.

Филемонд бичсэн захидал нь өөрийн эзэн Филемоныг дээрэмдээд Ром уруу зугтсан зарц Онесимын тухай хувийн захидал юм. Паул Онесимыг тэрээр уучилж болох тухай захидлын хамт эзэн уруу нь буцаан явуулжээ.

Мосегийн хууль Христэд хэрэгжсэн бөгөөд Христийн сайн мэдээний хууль үүнийг орлох болно гэдэгт Сүмийн иудей гишүүдийг итгүүлэхийн тулд Паул уг захидлыг еврейчүүдэд бичжээ.

1 ба 2 Тимот, Тит (мэ 64–65 он)

Анх удаа шоронгоос чөлөөлөгдсөний дараа Паул эдгээр захидлуудыг Ромд бичжээ.

Тимотыг үлдээсэн Ефест хожим нь эргэж ирнэ гэж бодон, тэнд гарч ирсэн үзэл бодлын зарим хэлбэрүүдийг зогсоохын тулд, Паул Ефесээр дайран аялжээ. Тэрээр үүргээ биелүүлэхэд нь түүнд зөвлөгөө өгч

урам хайрлахын тулд Тимотод анхныхаа захидлыг Македониос бичсэн бололтой.

Титэд бичсэн захидлаа Паул шоронгоос суллагдаад байсан үедээ бичжээ. Тэрбээр Титийн үйлчилж байсан Кретэд очсон байж магадгүй. Захидалд ихэвчлэн зөв шударгаар амьдрах хийгээд Сүмийн доторх сахилгын тухай өгүүлсэн байдаг.

Тимотод бичсэн хоёр дахь захидлаа Паул хоёр дахь удаагаа шоронд байх үеэр, тэрбээр амь насаараа хохирон алагдахын өмнөхөн бичжээ. Энэхүү захидал Паулын сүүлчийн үгсийг агуулж, тэрээр үхэлтэй тулгарсан үедээ гайхамшигт эр зориг хийгээд итгэл найдвартай байсныг харуулдаг.

ПАХОРАН

Мормоны Номон дахь, нифайчуудын гурав дахь ерөнхий шүүгч (Алма 50:39–40; 51:1–7; 59–62).

ПЕЛЕГ

Хуучин Гэрээнд, Еберийн хүү, Шемийн дөч. Түүний үед дэлхий хуваагджээ (Эхл. 10:22–25).

ПЕНТАТЕУХ. Дэд Хууль;

Египетээс Гарсан нь; Левит; Мосе; Тооллого; Хуучин Гэрээг; Эхлэлийг *мөн үз*

Хуучин Гэрээний эхний таван номонд Эхлэл, Египетээс Гарсан нь, Левит, Тооллого, түүнчлэн Дэд Хуульд өгсөн нэр. Иудейчүүд эдгээр номнуудыг Тора буюу Израилын хууль хэмээн үздэг. Эдгээр номнуудыг Мосе бичжээ (1 Ниф. 5:10–11).

ПЕНТЕКОСТ. Мосегийн Хуулийг

мөн үз

Мосегийн хуулийн нэг хэсэг болох Пентекостын баяр буюу анхны үр жимсний баяр Дээгүүр Өнгөрсний баярын дараа тавин өдөр болдог байжээ (Лев. 23:16). Пентекост бол ургацын баярыг тэмдэглэх явдал байсан бөгөөд Хуучин Гэрээнд энэ нь ургацын баяр буюу долоо хоно-

гуудын баяр хэмээн нэрлэгдсэн байдаг. Энэ бол Иерусалимд Төлөөлөгчид Ариун сүнсээр дүүрч тэгээд хэлүүдээр ярьсан үед тэмдэглэдэг байжээ (Үйлс 2; С ба Г 109:36–37).

ПЕТР

Шинэ Гэрээнд Петр эхлэн гарахдаа, Капернаумд эхнэртэйгээ хамт амьдардаг байсан, Бетсайдын загасчин Симеон буюу Симон (2 Петр 1:1) хэмээгддэг байв. Есүс Петрийн эхнэрийн ээжийг эдгээжээ (Марк 1:29–31). Петр өөрийн ах Андрейн хамт Есүс Христийн шавь байхаар дуудагдсан билээ (Мат. 4:18–22; Марк 1:16–18; Лук 5:1–11). Сефас, үзмэрч буюу чулуу гэсэн түүний арамей нэрийг Их Эзэн түүнд өгчээ (Иохан 1:40–42; ИСО Иохан 1:42). Шинэ Гэрээ Петрийн мөнх бус байдлын зарим сул талыг дурдсан байдаг ч гэсэн, тэрээр эдгээр сул талуудыг даван туулж, Есүс Христэд итгэх итгэлээрээ хүчтэй болсон билээ.

Есүс бол Христ бөгөөд Бурханы Хүү (Иохан 6:68–69) байсан гэдгийг үнэн сэтгэлээсээ хүлээн зөвшөөрсөн бөгөөд Их Эзэн түүнийг дэлхий дээрх хаант улсын түлхүүрүүдийг атгахаар сонгон авчээ (Мат. 16:13–18). Хувиралтын Уулан дээр Петр Мосе болон Елиасын нэгэн адилаар (Елиа) хувиран өөрчлөгдсөн Аврагчийг харжээ (Мат. 17:1–9).

Петр өөрийнхөө үед ахлах Төлөөлөгч байв. Аврагч нас барж, амилан мөн тэнгэрт өгсөн одсоны дараа Тэрээр Сүмийг хамтад нь дуудан, Иудас Искариотын оронд өөр Төлөөлөгч дуудах ажлыг удирдан чиглүүлжээ (Үйлс 1:15–26). Петр, Иохан хоёр төрөхөөсөө хазгар байсан нэг хүнийг эдгээж (Үйлс 3:1–16), мөн гайхамшигтай байдлаар шоронгоос суллагдсан байлаа (Үйлс 5:11–29; 12:1–19). Петрээр дамжин сайн мэдээ анх удаа харийнханд нээгдсэн билээ (Үйлс 10–11). Хожмын өдрүүдэд Иаков, Иохан хоёрын хамт Петр тэнгэрээс бууж ирэн Мелкизедек санваар хийгээд түүний түлхүүрүүдийг

Иосеф Смит Оливер Каудери нарт хүртгээжээ (С ба Г 27:12–13; 128:20).

Петрийн анхны захидал: Анхныхаа захидлыг Вавилоноос (Ромоос ч байж магадгүй) бичиж эдүгээ Бага Ази хэмээн нэрлэгддэг, удалгүй Христэд итгэгчдийг Неро хавчиж эхэлсэн тэр газар дахь Гэгээнтнүүдэд илгээжээ.

Бүлэг 1 нь Христ Гэтэлгэгч болж урьдчилан томилогдсон түүний үүргийн тухай өгүүлдэг. Бүлэг 2, 3 нь Христ бол Сүмийн гол тулгуур чулуу мөн гэдгийг, Гэгээнтнүүд дээд сурвалжит санваар атгадгийг, мөн Христ шорон дахь сүнснүүдэд номлосныг тайлбарлажээ. Бүлэг 4, 5 нь сайн мэдээ яагаад нас барагсдад номлогддогийг, мөн ахлагчид яагаад сүргийг тэжээх ёстойг тайлбарладаг.

Петрийн хоёр дахь захидал: Бүлэг 1 нь өөрсдийн дуудлага хийгээд сонгуульд бат итгэлтэй байхыг Гэгээнтнүүдэд ухуулжээ. Бүлэг 2 нь хуурамч багш нарын талаар сэрэмжлүүлжээ. Бүлэг 3-т хожмын өдрүүд хийгээд Христийн хоёр дахь ирэлтийн тухай өгүүлдэг.

ПИЛАТ, ПОНТИ

Иудад мэ 26–36 онд байсан Ромын захирагч (Лук 3:1). Тэрээр иудей хүмүүс түүнчлэн тэдний шашинд дургүй байсан бөгөөд хамгийн багаар нилээд хэдэн галилчуудыг цаазаар аваачжээ (Лук 13:1). Есүс Пилатын өмнө буруутгагдан, цовдлуулахаар ялагдсан билээ (Мат. 27:2, 11–26, 58–66; Марк 15; Лук 23; Иохан 18:28–19:38).

ПОРНОГРАФИ. Ариун явдал;

Завхайрал; Садар самууныг үз

ПРАТТ, ООРСОН

Өнөө үед Сүм сэргээгдсэний дараах анхны Арванхоёр Төлөөлөгчийн нэг (С ба Г 124:128–129). Иосеф Смитээр дамжуулан Их Эзэн түүнд илчлэлт өгөхөд тэрээр Сүмийн гишүүн болоод дөнгөж зургаан долоо хоног болж байв (С ба Г 34). Оорсон Пратт Сүмийн номлогч (С ба Г 52:26; 75:14)

байж мөн хэдэн жилийн турш Сүмийн түүхчээр үйлчилж байв.

ПРАТТ, ПАРЛИ ПАРКЕР

Оорсон Праттын ах, түүнчлэн өнөө үед Сүм сэргээгдсэний дараа дуудагдсан анхны Арванхоёр Төлөөлөгчийн нэг (С ба Г 124:128–129). 1830 оны арванхоёрдугаар сард Иосеф Смитээр дамжуулан Их Эзэн түүнд илчлэлт өгөхөд нилээд олон номлогчийн хүчин чармайлтын анхныхад Парли Пратт дуудагдсан байлаа (С ба Г 32; 50:37).

РАМЕУМПОТ

Мормоны Номонд нифайчуудаас урвасан зорамчууд дээр нь залбирдаг байсан өндөр индэр (Алма 31:8–14).

РАФАЕЛ. Тэнгэр элчүүдийг *мөн үз*

Бүх зүйлийн сэргээлтэд оролцсон, Их Эзэний нэг тэнгэр элч (С ба Г 128:21).

РАХЕЛ. Исаакийн хүү Иаковыг

мөн үз

Хуучин Гэрээнд, Иаковын эхнэр (Эхл. 29–31, 35). Тэр бас Иосеф, Бениамин хоёрын эх байлаа.

РЕБЕКА. Исаакийг *мөн үз*

Хуучин Гэрээний патриарх Исаакийн эхнэр (Эхл. 24–27). Ребека бол Есав, Иаков хоёрын эх юм (Эхл. 25:23–26).

РЕУБЕН. Израил; Исаакийн хүү

Иаковыг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Иаков Леа хоёрын ууган хүү (Эхл. 29:32; 37:21–22, 29; 42:22, 37). Реубен ууган хүү байсан ч гэсэн, нүглийн улмаас залгамжлах эрхээ алджээ (Эхл. 35:22; 49:3–4).

Реубений овог: Реубенд өгсөн Иаковын адислал Эхлэл 49:3 ба Дэд хууль 33:6-д байдаг. Хэдийгээр овог оршин тогтносоор байсан ч гэсэн, овгийн тоо алгуураар цөөрч, улс төрийн хувьд энэ нь бага ач холбогдолтой болжээ. Реубений залгамжлах эрх

Иосеф болон түүний хөвгүүдэд шилжсэн бөгөөд учир нь Иосеф бол Иаковын хоёр дахь эхнэр Рахелын ууган хүү байв (Шаст. дээд 5:1–2).

РЕУЕЛ. Иетрог үз

РЕХОБОАМ. Соломоныг мөн үз

Хуучин Гэрээнд, Соломон Хааны хүү. Тэрээр эцгээ залгамжилж Иерусалимд арван долоон жил хаанчилжээ (Хаад. дээд 11:43; 14:21, 31). Рехобоамын хаанчлалын үед, хаант улс умард дахь Израилын хаант улс болон өмнөд дэх Иудейн хаант улс болон хуваагджээ (Хаад. дээд 11:31–36; 12:19–20). Рехобоам Иудейн хаант улсыг захирч байв.

РИГДОН, СИДНЕЙ

1830-аад он болон 1840-өөд оны эхэн үед сэргээгдсэн Сүмийн анхны хөрвөгч бөгөөд удирдагч. Сидней Ригдон Сүмийн Тэргүүн Зөвлөлд Иосеф Смитийн нэгдүгээр зөвлөхөөр хэсэг хугацаанд үйлчилж байв (С ба Г 35; 58:50, 57; 63:55–56; 76:11–12, 19–23; 90:6; 93:44; 100:9–11; 124:126). Хожим нь тэрээр урваж, 1844 оны есдүгээр сард хөөгджээ.

РОМ. Ромын эзэнт гүрнийг мөн үз

Шинэ Гэрээнд, Италийн Тибер мөрөн дээр оршдог Ромын эзэнт гүрний нийслэл (Үйлс 18:2; 19:21; 23:11). Ромын засгийн газрын шоронгийн хоригдол байхдаа Паул сайн мэдээг Ромд заадаг байв (Ром 1:7, 15–16; Үйлс 28:14–31).

РОМЧУУДАД БИЧСЭН

ЗАХИДАЛ. Паул; Паулын захидлуудыг мөн үз

Шинэ Гэрээнд, Ромын Гэгээнтнүүдэд Паулын бичсэн захидал. Аюултай гэдэг нь илэрхий байсан Иерусалим уруу тэр явахаар бодож байв. Хэрэв тэрээр амь насаа аварвал, дараа нь Ромд ирнэ гэж найдаж байв. Захидал нь өөрийг нь хүлээж авахад тэндхийн Сүмийг зарим талаар бэлтгэх зорилготой байв. Энэ нь

тэрчлэн маргаантай байсан зарим номлолын нотолгоог агуулсан хэмээн тооцогдож болох бөгөөд тухайн үед Паул үүнийг эцэслэн шийдвэрлэгдсэн гэж үзэж байв.

Бүлэг 1 нь ромчуудад илгээсэн Паулын мэндчилгээг агуулдаг. Бүлэг 2–11 нь итгэл, ажил болон ач ивээлийн тухай номлолуудын талаарх хэд хэдэн тунхаглалыг багтаадаг. Бүлэг 12–16 нь хайр, үүрэг хариуцлага болон цэвэр ариун байдлын тухай амьдралд хэрэгжүүлэхүйц сургаалуудыг агуулдаг.

РОМЫН ЭЗЭНТ ГҮРЭН. Ромыг мөн үз

Эртний Ромын эзэнт гүрэн. Төлөөлөгчдийн үед Ромын эзэнт гүрэн дэлхийн хамгийн хүчирхэг гүрний нэг байв. Энэ нь Ефрат, Дунай, Рейн, Атлантын далай түүнчлэн Сахарын цөлийн хоорондох бүх газар нутгийг өөртөө багтаадаг байв. мээ 63 онд Помпей Иерусалимыг эзлэн авахад Палестин дагуул улс болжээ. Ромчууд иудейчүүдэд олон боломжийг амласан хэдий ч, иудейчүүд Ромын дэглэмд дургүйцэж мөн байнга эсэргүүцдэг байлаа.

Ромын иргэн Паул, эзэнт гүрэнд хамгийн өргөн хэрэглэгддэг грек хэлийг ашиглан эзэнт гүрэн даяар сайн мэдээг түгээжээ.

Цейзарийн юмсыг Цейзарьт өг, **Мат.** 22:17–22. Паул Ромын иргэний хувьд эрхээ шаардав, **Үйлс** 16:37–39 (Үйлс 22:25–29).

РУТ. Боазыг мөн үз

Хуучин Гэрээнд, израил хүмүүс байсан Наоми Елимелек нарын моаб бэр. Нөхрөө нас барсны дараа Рут Наомигийн хамаатан Боазтай гэрлэжээ. Тэдний хүү Обед нь Давид болон Христийн өвөг дээдэс байв. Рутын түүх нь израил бус хүн Израилын сүрэгт хөрвөгдөх явдлыг аятай сайхнаар харуулжээ. Рут хуучин бурхан болон хуучин амьдралаасаа татгалзаж, Израилын Бурханд

үйлчлэхээр итгэл бүхий гэр бүлтэй нэгдсэн билээ (Рут 1:16).

Рутын ном: Бүлэг 1 нь Моаб дахь Елимелек болон түүний гэр бүлийн амьдралыг дүрсэлдэг. Нөхрүүдээ нас барсны дараа Наоми, Рут хоёр Бетлехем уруу явжээ. Бүлэг 2 нь Рут Боазын талбайд хаягдсан тариан түрүүг түүснийг тайлбарладаг. Бүлэг 3-т Рут үтрэм уруу явж, Боазын хөлд хэрхэн хэвтэхийг Наоми зааж өгсөн тухай өгүүлдэг. Бүлэг 4 нь Рут Боазтай хэрхэн гэрлэсэн тухай түүх юм. Давид болон Христ удмаар нь дамжин гарч ирсэн Обед хүү тэдэнд байлаа.

САГСУУРАХ. Бардамналыг үз

САДАР САМУУН. Ариун явдал;

Бэлгийн харилцааны ёс суртахуунгүй байдал;
Завхайрал; Ижил үйстэнтэй хурьцах; Тачаалалт,
Тачаангуйг *мөн үз*

Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хууль бус бэлгийн харилцаа. Садар самуун нь ерөнхийдөө эхнэр болон нөхрөөс бусад хэн нэгэнтэй бэлгийн харьцаанд орохыг хэлдэг боловч судруудад энэ нь гэрлээгүй хүмүүст мөн хамаатай байдаг.

Заримдаа садар самуун нь үндэстэн болон бүх хүмүүс Их Эзэний замаас урвасны тэмдэг болон хэрэглэгддэг (Тоол. 25:1–3; Езек. 16:15–59; Иерем. 3:6–10; Хосеа 4).

Энэ агуу ёсон бус явдал хийгээд нүглийг Бурханы эсрэг үйлдэхийг Иосеф хүсээгүй, **Эхл.** 39:7–12. Садар самууныг бүү үйлд, **Ег.** 20:14. Эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй хэдийн садар самууныг үйлдсэн байдаг, **Мат.** 5:28. Завхайрагчид ч, садар самууныг үйлдэгчид ч Бурханы хаант улсыг өвлөх нь үгүй, **1 Кор.** 6:9–10. Садарлагч эрчүүдийг болон завхайрагчдыг Бурхан шүүх болно, **Евр.** 13:4. Садар самуун нь гэмгүй цусыг урсгах болон Ариун Сүнснийг үгүйсгэхээс бусад бүх

нүглээс хамгийн жигшүүртэй нь билээ, **Алма** 39:3–5. Садар самууныг үйлдэж мөн наманчилдаггүй тэрээр зайлуулагдах болно, **С ба Г** 42:23–26. Хэрэв хэн нэг нь зүрх сэтгэлдээ садар самууныг үйлдэх аваас тэдэнд Сүнс байх нь үгүй, **С ба Г** 63:14–16.

САДУКАЙЧУУД. Иудейчүүдийг *мөн үз*

Иудейчүүдийн дундах цөөн боловч улс төрийн талаар хүчирхэг бүлэг буюу нийгмийн давхарга. Тэд Мосегийн хуулийн үгсийг дагах өөрсдийн тууштай итгэлээрээ болон сүнсний бодит байдал, тэнгэр элчүүд, мөн тэрчлэн гэтэлгэл болон мөнхийн амьдралын номлолуудыг эсэргүүцдэгээрээ нэрд гарсан байлаа (**Марк** 12:18–27; **Үйлс** 4:1–3; 23:7–8).

САЙН МЭДЭЭ. Гэтэлгэлийн төлөвлөгөө; Христийн номлол; Эрин үеийг *мөн үз*

Есүс Христийн цагаатгалаар дамжин хэрэгжих боломжтой болсон Бурханы авралын төлөвлөгөө. Сайн мэдээ нь хүн төрөлхтнийг Бурханы дэргэд эргэн очиход нь шаардлагатай мөнхийн үнэн буюу хуулиуд, гэрээнүүд хийгээд ёслолуудыг өөртөө багтаадаг. Бурхан бүрэн сайн мэдээг Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан арван есдүгээр зуунд дэлхийд сэргээсэн билээ.

Бүх дэлхийгээр явж сайн мэдээг тунхаглагтун, **Марк** 16:15. Хурганы сайн мэдээний тодорхой бөгөөд эрхэм үнэт хэсгүүд далдлагдсан байв, **1 Ниф.** 13:32. Энэ бол миний сайн мэдээ, **3 Ниф.** 27:13–21 (**С ба Г** 39:6). Мормоны Ном бүрэн сайн мэдээг агуулдаг, **С ба Г** 20:8–9 (**С ба Г** 42:12). Энэ бол сайн мэдээ, **С ба Г** 76:40–43. Мелкизедек Санваар сайн мэдээг удирддаг, **С ба Г** 84:19. Хүн болгон бүрэн сайн мэдээг өөрийнхөө хэл дээр сонсох болно, **С ба Г** 90:11. Сайн мэдээг Хүү нас барагсдын сүнснүүдэд номлож байв, **С ба Г** 138:18–21, 28–37. Сайн мэдээ эхлэлээс номлогдож байв, **Моце** 5:58. Сайн мэдээний

анхдагч зарчмууд хийгээд ёслолууд дүрслэгдэв, **ИТ** 1:4.

САЙН МЭДЭЭ, ТҮҮНИЙ

СЭРГЭЭЛТ. Сайн мэдээний сэргээлтийг үз

САЙН МЭДЭЭНИЙ АНХДАГЧ

ЗАРЧМУУД. Ариун Сүнс;
Баптисм, Баптисм хүртээх;
Итгэл; Наманчлах,
Наманчлалыг мөн үз

САЙН МЭДЭЭНИЙ СЭРГЭЭЛТ.

Бага Иосеф Смит; Сайн мэдээ;
Урвалт; Эрин үеийг мөн үз

Бурхан өөрийн сайн мэдээний үнэнүүд болон ёслолуудыг дэлхий дээр хүмүүний дунд дахин үндэслэн байгуулсан сэргээлт. Есүс Христийн сайн мэдээ нь Христийн Төлөөлөгчдийн дэлхий дээрх тохиноуллын дараах урвалтаас хойш дэлхийгээс байхгүй болсон байлаа. Тэрхүү урвалт нь сайн мэдээг сэргээх шаардлагыг бий болгосон юм. Дэлхий дээрх хүмүүст өгсөн үзэгдлүүд, тэнгэр элчүүдийн тохиноулал хийгээд илчлэлтүүдээр дамжуулан Бурхан сайн мэдээг сэргээсэн билээ. Сэргээлт нь Бошиглогч Иосеф Смитээр эхэлж (ИС—Т 1:1–75; С ба Г 128:20–21) Их Эзэний амьд бошиглогчдын ажлаар дамжин эдүгээг хүртэл үргэлжилсээр байгаа билээ.

ЭЗЭНий өргөө уулсын оргил дээр баригдах болно, **Иса.** 2:2 (Мика 4:2; 2 Ниф. 12:2). Бурхан ер бусын гайхамшигт, гайхалтай зүйлсийг хийх болно, **Иса.** 29:14 (2 Ниф. 25:17–18; С ба Г 4:1). Хэзээ ч устгагдашгүй хаант улсыг Бурхан байгуулах болно, **Дан.** 2:44. Елиа эргэж ирэн бүх зүйлийг сэргээх болно, **Мат.** 17:11 (Марк 9:12; С ба Г 77:14). Бүх зүйлийг сэргээх цаг ирэх болно, **Үйлс** 3:21 (С ба Г 27:6). Цаг хугацааны бүрэн байдлын эрин үед Бурхан бүхнийг нэгд хамтад нь цуглуулах болно, **Ефес** 1:10. Номлох үүрдийн сайн мэдээ бүхий өөр нэгэн тэнгэр эл-

чийг би харав, **Илч.** 14:6. Бүрэн сайн мэдээ Харийнханд ирэх болно, **1 Ниф.** 15:13–18. Иудейчүүд үнэн сүмд сэргээгдэх болно, **2 Ниф.** 9:2. Хожмын үед үнэн ирэх болно, **3 Ниф.** 16:7. Аароны Санваарыг би та нарт хүртээе, **С ба Г** 13:1 (ИС—Т 1:69). Хожмын үеийн төлөө хаант улсын түлхүүрүүдийг би та нарт даатгалаа, **С ба Г** 27:6, 13–14 (С ба Г 128:19–21). Израилын овгуудыг хамтад нь цуглуулж, бүх зүйлийг сэргээгтүн, **С ба Г** 77:9. Энэ эрин үеийн түлхүүрүүд даатгагдав, **С ба Г** 110:16 (С ба Г 65:2). Цаг хугацааны бүрэн байдлын эрин үед санваар өгөгдөв, **С ба Г** 112:30. Би хоёр Хүнийг харав, **ИС—Т** 1:17. Елиагийн гараар би санваарыг та нарт илчлэх болно, **ИС—Т** 1:38 (Малах. 4:5–6).

САЙН МЭДЭЭНҮҮД.

Зебедеен хүү; Лук; Марк,
Матайг үз

Шинэ Гэрээний дөрвөн номонд агуулагддаг, Есүсийн мөнх бус амьдрал хийгээд түүний тохиноулалд хамаарах үйл явдлуудын тухай дөрвөн цэдэг буюу гэрчлэлүүд. Эдгээр нь Матай, Марк, Лук болон Иоханаар бичигдэж, Христийн амьдралын тухай гэрчлэлүүд болон цэдэглэгджээ. Мормоны Номон дахь 3 Нифайн ном нь олон талаараа Шинэ Гэрээний эдгээр дөрвөн Сайн Мэдээтэй төстэй юм.

Шинэ Гэрээний номнууд анх грекээр бичигджээ. Госпелтой утга дүйх грек үг нь сайн мэдээ юм. Сайн мэдээ гэсний учир бол Есүс Христ бүх хүн төрөлхтнийг үхлээс гэтэлгэж мөн хувь хүн бүрийг ажлуудынх нь дагуу шагнах цагаатгалыг хийснийх юм (Иохан 3:16; Ром 5:10–11; 2 Ниф. 9:26; Алма 34:9; С ба Г 76:69).

Сайн Мэдээний зохицол: Матай, Марк, Лук, болон Иохан дахь Аврагчийн сургаалуудыг өөр хооронд нь болон хожмын үеийн илчлэлттэй дараах байдлаар харьцуулж болно:

САЙН МЭДЭЭНҮҮДИЙН ЗОХИЦОЛ

Үйл явдал	Матай	Марк	Лук	Иохан	Хожмын үеийн илчлэлт
Есүс Христийн Угийн бичиг	1:2–17		3:23–28		
Иохан Баптистын төрөлт			1:5–25, 57–58		
Есүсийн төрөлт	2:1–15		2:6–7		1 Ниф. 11:18–20; 2 Ниф. 17:14; Мозая 3:5–8; Алма 7:10; Хил. 14:5–12; 3 Ниф. 1:4–22
Симеон болон Аннагийн бошиглолууд			2:25–39		
Ариун сүмд зочилсон нь (Дээгүүр өнгөрсний баяр)			2:41–50		
Иоханы тохинуул-лын эхлэл	3:1, 5–6	1:4	3:1–3	1:6–14	
Есүсийн баптисм хүртэлт	3:13–17	1:9–11	3:21–22	1:32–34	1 Ниф. 10:7–10; 2 Ниф. 31:4–21
Есүст тохиолдсон уруу таталтууд	4:1–11		4:1–13		
Иохан Баптистын гэрчлэл				1:15–36	С ба Г 93:6–18, 26
Кана дахь гэрлэлтийн хурим (Есүсийн анхны гайхамшиг)				2:1–11	
Ариун сүмийг анх удаа цэвэршүүлсэн нь				2:14–17	

Үйл явдал	Матай	Марк	Лук	Иохан	Хожмын үеийн илчлэлт
Никодемтой уулзсан нь				3:1–10	
Худаг дээрх самари эмэгтэй				4:1–42	
Назарт Есүсийг эсэргүүцсэн нь	4:13–16		4:16–30		
Загасчид хүмүүний загасчид байхаар дуудагдав	4:18–22	1:16–20			
Загасны торыг гайхамшигтайгаар дүүргэсэн нь			5:1–11		
Иайрын охиныг босгосон нь	9:18–19, 23–26	5:21–24, 35–43	8:41–42, 49–56		
Цус алддаг эмэгтэйг эдгээсэн нь	9:20–22	5:25–34	8:43–48		
Арванхоёрыг дуудсан нь	10:1–42	3:13–19, 6:7–13	6:12–16, 9:1–2, 12:2–12, 49–53		1 Ниф. 13:24–26, 39–41; С ба Г 95:4
Бэлэвсэн эмэгтэйн хүүг босгосон нь			7:11–15		
Христийн хөлийг тосолсон нь			7:36–50	12:2–8	
Шуургыг намдаасан нь		4:36–41	8:22–25		
Далыг дуудсан нь			10:1		С ба Г 107:25, 34, 93–97
Маш олон чөтгөрийг гахайнд оруулсан нь		5:1–20			
Уулан дээрх Номлол	5–7		6:17–49		3 Ниф. 12–14

Үйл явдал	Матай	Марк	Лук	Иохан	Хожмын үеийн илчлэлт
Есүсийн сургаалт зүйрлэлүүд нь энгийн зүйлс болон үйл явдлуудыг үнэнтэй харьцуулсан богино хэмжээний түүхүүд юм. Ихэнхдээ сүнслэг үнэнүүдийг заахдаа тэдгээрийг Есүс ашигладаг байв.					
Тариачин:	13:3–9, 18–23	4:3–9, 14–20	8:4–8, 11–15		
Зэрлэг өвс:	13:24–30, 36–43				С ба Г 86:1–7
Гичийн үр:	13:31–32	4:30–32	13:18–19		
Исгэх хөрөнгө:	13:33		13:20–21		
Талбайд нуусан эрдэнэ:	13:44				
Агуу үнэт сувд:	13:45–46				
Загасчны тор:	13:47–50				
Өрхийн тэргүүн:	13:51–52				
Төөрсөн хонь:	18:12–14		15:1–7		
Алдагдсан зоос			15:8–10		
Үрэлгэн хүү:			15:11–32		
Энэрэнгүй бус зарц:	18:23–35				
Сайн самари хүн:			10:25–37		
Шударга бус даамал:			16:1–8		
Лазар баян хүн хоёр:			16:14–15, 19–31		
Шударга бус шүүгч:			18:1–8		
Сайн Хоньчин:				10:1–21	3 Ниф. 15:17–24

Үйл явдал	Матай	Марк	Лук	Иохан	Хожмын үеийн илчлэлт
Талбайд хөдөл-мөрлөгсөд:	20:1–16	10:31			
Мина:			19:11–27		
Хоёр хөвгүүн:	21:28–32				
Ёс бус газрын эзэн:	21:33–46	12:1–12	20:9–20		
Хааны хүүгийн хурим:	22:1–14		14:7–24		
Арван онгон охин:	25:1–13		12:35–36		С ба Г 45:56–59
Талантууд:	25:14–30				
Хонь, ямаанууд:	25:31–46				
Таван мянган хүнийг хооллосон нь	14:16–21	6:33–44	9:11–17	6:5–14	
Есүс усан дээгүүр алхав	14:22–33	6:45–52		6:16–21	
Христийн тухай Петрийн гэрчлэл	16:13–16	8:27–29	9:18–20		
Петрт хаант улсын түлхүүрүүд амлагдав	16:19				
Амьдралын талхны тухай Номлол				6:22–71	
Хүндэтгэлийн өдөр хараагүй хүнийг эдгээсэн нь				9:1–41	
Хувиралт, санваарын түлхүүрүүд даатгагдав	17:1–13	9:2–13	9:28–36		С ба Г 63:20–21; 110:11–13

Үйл явдал	Матай	Марк	Лук	Иохан	Хожмын үеийн илчлэлт
Хүүхдүүдийг адисалсан нь	19:13–15	10:13–16	18:15–17		
Их Эзэний залбирал	6:5–15		11:1–4		
Лазар эдгэрэв				11:1–45	
Ялгуусан ирэлт	21:6–11	11:7–11	19:35–38	12:12–18	
Мөнгө хүүлэгчдийг ариун сүмээс хөөв	21:12–16	11:15–19	19:45–48		
Бэлэвсэн эмэгтэйн бяцхан хүү		12:41–44	21:1–4		
Хоёрдахь Ирэлтийн тухай бодрол	24:1–51	13:1–37	12:37–48; 17:20–37; 21:5–38		С ба Г 45:16–60; ИС—М 1:1–55
Арван уяман өвчтөнийг эдгээсэн нь			17:12–14		
Есүсийн сүүлчийн Дээгүүр өнгөрөх баяр, ариун ёслолыг танилцуулсан нь, Арванхоёрт өгсөн зааврууд, шавь нарынхаа хөлийг угаасан нь	26:14–32	14:10–27	22:1–20	13–17	
Есүс Гетсеманид зовсон нь	26:36–46	14:32–42	22:40–46		2 Ниф. 9:21–22; Мозая 3:5–12; С ба Г 19:1–24
Есүс бол жимсний мод	15:1–8				
Иудасын урвалт	26:47–50	14:43–46	22:47–48	18:2–3	
Каиафын өмнө авчрагдсан нь	26:57	14:53	22:54, 66–71	18:24, 28	

Үйл явдал	Матай	Марк	Лук	Иохан	Хожмын үеийн илчлэлт
Пилатын өмнө авчрагдав	27:2, 11-14	15:1-5	23:1-6	18:28-38	
Херодын өмнө авчрагдав			23:7-10		
Есүсийг ташуурдаж мөн шоолов	27:27-31	15:15-20		19:1-12	
Цовдлуулалт	27:35-44	15:24-33	23:32-43	19:18-22	Хил. 14:20-27; 3 Ниф. 8:5-22; 10:9
Амилалт	28:2-8	16:5-8	24:4-8		
Есүс шавь нартаа үзэгдсэн нь		16:14	24:13-32, 36-51	20:19-23	
Есүс Томаст үзэгдсэн нь				20:24-29	
Дээш одолт		16:19-20	24:50-53		

САЙН ХОНЬЧИН. Есүс Христийг мөн үз

Есүс Христ бол Сайн Хоньчин мөн. Бэлэг тэмдгээр бол, түүний дагалдагчид нь Есүсийн хариулдаг хонин сүрэгтэй адилхан юм.

Эзэн бол миний хоньчин, **Дуул.** 23:1. Тэр хоньчин мэт сүргээ хариулдаг, **Иса.** 40:11. Тийнхүү би хонин сүргээ эрж олох болно, **Езек.** 34:12. Би бол сайн хоньчин мөн, **Иохан** 10:14-15. Есүс бол хонин сүргийн агуу хоньчин билээ, **Евр.** 13:20. Тэрээр өөрийн хонийг тоолдог мөн хонь нь түүнийг мэддэг, **1 Ниф.** 22:25. Уг сайн хоньчин Христ болох өөрийн нэрээр та нарыг дууддаг, **Алма** 5:38, 60. Мөн нэг хороо, мөн нэг хоньчин байх болно, **3 Ниф.** 15:21 (Иохан 10:16).

САЛЕМ. Иерусалим;
Мелкизедекийг мөн үз

Мелкизедекийн захирч байсан Хуу-

чин Гэрээний хот. Энэ нь одоогийн Иерусалим байрлаж буй газарт байсан бололтой. Салем гэдэг нэр нь еврей хэлний амар амгалан гэсэн үгтэй маш ойролцоо утгатай.

Салемын хаан Мелкизедек талх болон дарсыг урагш авчирсан юм, **Эхл.** 14:18. Салемын хаан Мелкизедек бүхний дээд Бурханы санваартан байв, **Евр.** 7:1-2. Мелкизедек нь Салемын нутгийн хаан байв, **Алма** 13:17-18.

САМ. Лихай; Нифайн эцгийг мөн үз

Мормоны Номонд Лихайн гурав дахь хүү (1 Ниф. 2:5). Тэрээр Их Эзэнийг дагахыг сонгосон шударга ариун хүн байв (1 Ниф. 2:17; 2 Ниф. 5:5-6; Алма 3:6).

САМАРИ. Самаричуудыг мөн үз

Хуучин Гэрээнд Израилын Умард Хаант Улсын нийслэл хот (Хаад, дээд

16:23–24). Дов дээр цэргийн хүчирхэг байрлалтай учраас ассиричууд хотыг гурван жил бүсэлсний дараа сая эзэлжээ (Хаад. дэд 17:5–6). Херод үүнийг дахин босгоод Себасте хэмээн нэрлэжээ. Шинэ Гэрээний үед, Иорданы умард хэсгийн Палестины төв дүүргийг бүхэлд нь Самари хэмээн нэрлэдэг байв.

САМАРИЧУУД. Самариг мөн үз

Израилын Умард Хаант Улс ассиричуудад эзлэгдсэний дараа Самарид амьдарч байсан библийн хүмүүс. Самаричуудын зарим нь израил зарим нь харийнхан байв. Тэд иудейчүүдийн болон үнэн Бурханыг мэддэггүй холимог шашны итгэл бишрэл хийгээд зан үйлтэй байв. Лук 10:25–37 дахь сайн самари хүний сургаалт зүйрлэл нь самаричууд израилчуудын шашнаас урвасан учраас самаричуудын эсрэг иудейчүүдийн хөгжүүлсэн үзэн ядалтыг харуулдаг. Их Эзэн сайн мэдээг самаричуудад заахыг Төлөөлөгчдөд зааварласан байдаг (Үйлс 1:6–8). Филип Самари дахь хүмүүст Христийн сайн мэдээг амжилттай номлож мөн тэдний дунд олон гайхамшигийг үйлджээ (Үйлс 8:5–39).

САМСОН

Хуучин Гэрээн дэх Израилын арванхоёр дахь шүүгч. Тэрээр бие бялдрынхаа агуу хүч чадлаар алдартай байсан хэдий ч, ёс суртахуунгүй зарим сонголт хийгээд үйлдлээрээ ухаан мулгуу байжээ (Шүүгч. 13:24–16:31).

САМУЕЛ, ЛЕМЕН ХҮН

Аврагчийг төрөхийн дөнгөж өмнөхөн нифайчуудад зааж мөн сэрэмжлүүлэхээр Их Эзэний илгээсэн, Мормоны Номон дахь лемен бошиглогч. Самуел Есүс Христийн төрөлт болон үхэлтэй холбогдсон тэмдгүүд хийгээд нифайчуудын устгалын тухай бошиглосон билээ (Хил. 13–16).

САМУЕЛ, ХУУЧИН ГЭРЭЭНИЙ БОШИГЛОГЧ

Елкана, Ханна хоёрын хүү Самуел, ээжийнхээ залбирлуудын хариу болон төржээ (1 Сам. 1). Хүүхэд байхад нь түүнийг Шилогийн асарт дээд санваартан Елигийн халамжинд өгчээ (1 Сам. 2:11; 3:1). Самуелыг залуухан байхад бошиглогч байхаар Их Эзэн дуудсан байна (1 Сам. 3). Елиг нас барсны дараа Самуел агуу бошиглогч, Израилын шүүгч болсон бөгөөд хууль, дэг журам болон шашны байнгын шүтлэгийг тэр нутагт дахин сэргээжээ (1 Сам. 4:15–18; 7:3–17).

1 Сам. 28:5–20 нь Саул хааны хүсэлтээр Ендорын төлөгч эмэгтэй Самуелыг үхлээс буцаан авчирсан тухай шастирыг агуулдаг. Төлөгч эмэгтэй буюу сүнсний бусад хэрэгсэл бошиглогчийг өөрийнх нь хүсэлтээр бошиглогч гарч ирэхэд нөлөөлж чадахгүй учраас энэ нь Бурханаас ирсэн үзэгдэл байж чадахгүй (1 Сам. 28:20; 31:1–4).

1, 2 Самуелын ном: Зарим Библид 1, 2 Самуел нь нэг ном байдаг. Бусдад нь хоёр ном байдаг. Номнууд нь Самуелын төрөлтөөс Давид хааны нас нөгчихийн өмнөх 130 жил орчим хугацааг хамардаг.

1 Самуелын ном: Бүлэг 1–4-д Их Эзэн Елигийн гэр бүлийг зүхэж, шийтгэснийг хийгээд Самуелыг дээд санваартан бөгөөд шүүгчээр дуудагдсаных дүрсэлдэг. Бүлэг 4–6 нь гэрээний авдар хэрхэн филистчүүдийн гарт орсон тухай өгүүлдэг. Бүлэг 7–8 нь хуурамч бурхад болон ёс бус хаантай байх тухайд Самуелын сэрэмжлүүлэг юм. Бүлэг 9–15 нь Саулын хаанаар сонгогдсон хийгээд хааны хувьд хэрхэн хаанчилсныг дүрсэлдэг. Бүлэг 16–31 нь Давид болон тэрээр хэрхэн хүчтэй болсон хийгээд Голиатыг алсан Давидыг Самуел онцгойлон адисалсан тухай өгүүлдэг. Саул Давидыг үзэн яддаг байсан бөгөөд Давид Саулыг алахыг эсэргүүцдэг байсан хэдий ч, тэрээр тийнхүү үйлджээ.

2 *Самуелын ном*: Ном нь Иудейн мөн эцэст нь бүх Израилын хаан болсон Давидын хаанчлалын нарийн ширийнийг агуулдаг. Бүлэг 1–4 нь Давидыг иудейчүүдийн хаан болсны дараа түүний дагалдагчид болон Саулыг дагалдагчдын хоорондох урт удаан тэмцлийг харуулдаг. Бүлэг 5–10 нь Давид олон нутагт хүчтэй болсон тухай харуулдаг. Бүлэг 11–21 нь Давид өөрийн нүгэл болон гэр бүлийнх нь доторх эсэргүүцлийн улмаас түүний сүнсний хүч чадлын бууралтыг харуулдаг. Бүлэг 22–24 нь Бурхантай эвлэрэх гэсэн Давидын оролдлогуудыг дүрсэлдэг.

САНАЛ ӨГӨХ. Нийтийн дэмжлэгийг үз

САНВААР. Аароны Санваар;
Мелкизедек Санваар;
Санваарын тангараг ба гэрээ;
Санваарын түлхүүрүүд;
Томилолт; Томилох; Хүч; Эрх мэдлийг мөн үз

Хүмүүний авралын тулд Бурханаас хүнд өгдөг бүх зүйлд үйлдэх эрх мэдэл хийгээд хүч (С ба Г 50:26–27). Санваар атгадаг Сүмийн эрэгтэй гишүүд чуулгуудад зохион байгуулагдаж, түүнчлэн Сүмд ёслолуудыг үйлдэх хийгээд захиргааны тодорхой үүргүүдийг гүйцэтгэх эрх мэдэлтэй болдог.

Тэдний тосолгоо нь үеийн үед тахилчийн ажил байх болно, Ег. 40:15 (Тоол. 25:13). Би та нарыг томилсон юм, **Иохан** 15:16. Та нар ариун санваар дээр, сүнслэг байшин болон баригддаг буюу, **1 Петр** 2:5. Та нар бол сонгогдсон угсаа, хаант тахилч нар, **1 Петр** 2:9 (Ег. 19:6). Өөрсдийн үлэмжийн итгэл хийгээд сайн үйлүүдийн учир эрэгтэйчүүд дээд санваартнууд хэмээн дуудагддаг бөлгөө, **Алма** 13:1–12. Баптисм хүртээх хүчийг би чамд өгье, **3 Ниф**. 11:21. Та нар Ариун Сүнсийг өгөх хүчтэй байх болно, **Моро**. 2:2. Бошиглогч Елиагийн гараар би та нарт санваарыг илчлэх болно, **С ба Г** 2:1

(ИС—Т 1:38). Их Эзэн санваарыг түүнчлэн Аарон болон түүний үр удам дээр батлав, **С ба Г** 84:18. Энэ агуу санваар нь сайн мэдээнд үйлчилдэг, **С ба Г** 84:19. Тэрээр Мосег, мөн Ариун Санваарыг тэрчлэн тэдний дундаас гаргаж авсан билээ, **С ба Г** 84:25. Санваарын тангараг хийгээд гэрээ дүрслэгдэв, **С ба Г** 84:33–42. Санваар нь та нарын эцгүүдийн удмаар дамжиж үргэлжлэн ирсэн бөлгөө, **С ба Г** 86:8. Сүмд хоёр санваар буй, **С ба Г** 107:1. Эхний санваар нь Бурханы Хүүгийн Жаягийн дагуух Ариун Санваар юм, **С ба Г** 107:2–4. Санваарын эрхүүд тэнгэрийн хүчнүүдтэй салшгүй холбоотой байдаг, **С ба Г** 121:36. Хүч буюу нөлөө нь санваарын ариун журмаар биш аваас, тэтгэгдэн байж чадахгүй буюу ёсгүй, **С ба Г** 121:41. Сүмийн итгэлтэй, зохистой эрэгтэй гишүүн бүр санваарыг хүлээн авч болно, **С ба Г** АТ—2. Хүн Бурханаас дуудагдах ёстой гэдэгт бид итгэдэг, **ИТ** 1:5.

САНВААР, ААРОНЫ. Аароны санваарыг үз

САНВААР, МЕЛКИЗЕДЕКИЙН. Мелкизедек санваарыг үз

САНВААР, ТҮҮНИЙ ТҮЛХҮҮРҮҮД. Санваарын түлхүүрүүдийг үз

САНВААРААР МЭРГЭШИХ

Дэлхийгээс ашиг хийгээд магтаал олохын тулд номлохын хамт дэлхийд өөрсөддөө алдрыг олдог хүмүүс; тэд Сионы сайн сайхныг эрэлхийлдэггүй (2 Ниф. 26:29).

Бурханы хонин сүргийг хариул, гэхдээ албадлагаар бус, **1 Петр** 5:2. Ашиг олохын тулд байгуулагддаг сүмүүд дорд үзэгдэх ёстой, **1 Ниф**. 22:23 (Морм. 8:32–41). Санваараар мэргэших явдал мөн алдсуудын учир Есүс цовдлогдох болно, **2 Ниф**. 10:5. Санваараар мэргэших нь энэ хүмүүсийн дунд албаар тулгагдсан

байваас энэ нь тэдний бүрэн устгалын шалтгаан болохсон бөлгөө, **Алма** 1:12. Харийнхан бүх төрлийн санваараар мэргэших явдлаар дүүрэх болно, **3 Ниф.** 16:10.

САНВААРТАН, ААРОНЫ

САНВААР. Аарон, Мосегийн ах; Аароны санваар; Дээд санваартныг *мөн үз*

Аароны санваарын нэг албан тушаал. Эрт дээр үед Левийн санваар дахь дээд санваарыг зөвхөн Аарон болон түүний удмынхан атгадаг байжээ. Христ Мосегийн хуулийг гүйцэлдүүлснээр энэхүү хязгаарлалтыг үгүй болгожээ.

Сэргээгдсэн Сүм дэх санваартны үүргүүд дүрслэгдэв, **С ба Г** 20:46–52.

САНВААРТАН, МЕЛКИЗЕДЕК

САНВААР. Дээд санваартан; Мелкизедек санваарыг *мөн үз*

Бусдын төлөө шашны ёслолуудыг гүйцэтгэж мөн Бурханд ханддаг хүн. Судруудад санваартнууд нь ихэвчлэн Мелкизедекийн жаягийн дагуух дээд санваартнууд байх нь олонтаа тохиолддог (**Алма** 13:2). Амилуулалтын дараа Бурханы бүрэн алдар сууг хүлээн авах тэд Селестиел дэлхийд санваартнууд хийгээд хаад болдог.

Мелкизедек бол хамгийн дээд Бурханы тахилч байв, **Эхл.** 14:18. Мелкизедекийн хэргэмийн дагуу чи бол мөнхийн тахилч юм, **Дуул.** 110:4 (Евр. 5:6; 7:17, 21). Христ биднийг Бурханд буюу өөрийн Эцэгт хаад болон тахилчид болгосон билээ, **Илч.** 1:6 (Илч. 5:10; 20:6). Их Эзэн Бурхан өөрийн ариун жаягийн дагуу санваартнуудыг томилсныг санагтун, **Алма** 13:1–20. Зөв шударгыг үйлдэгчдийн амилуулалтад урагш гарч ирэх тэд бол санваартнууд хийгээд хаад болой, **С ба Г** 76:50, 55–60.

САНВААРЫН ТАНГАРАГ БА

ГЭРЭЭ. Гэрээ; Санваар; Тангаргийг *мөн үз*

Амлалтууддаа үнэнч хийгээд итгэлтэй байхын тулд тангарагладаг.

Гэрээ бол хоёр талын хоорондох чанд амлалт мөн. Аароны Санваар нь зөвхөн гэрээгээр хүлээн авагддаг. Мелкизедек санваартнууд санваарыг үгээр үйлдээгүй тангаргаар мөн түүнчлэн гэрээгээр хүлээн авдаг. Санваартнуудын хувьд итгэлтэй байж мөн Бурханаас чиглүүлсний дагуу өөрсдийн дуудлагаа эрхэмлэн гүйцэтгэхэд, тэрээр тэднийг адисладаг. Эцсээ хүртэл тэвчээртэй байж мөн тэднээс түүний хүссэн болгоныг хийдэг хүмүүс Эцэгт байгаа бүхнийг хүлээн авах болно (**Сба Г** 84:33–39).

Их Эзэн Абрахамтай гэрээ байгуулж, мөн Абрахам дуулгавартай дагав, **Эхл.** 15:18; 17:1; 22:16–18. Езекиелийн үед санваартнууд сүргээ тэжээдэггүй байв, **Езек.** 34:2–3. Малахийн үед санваартнууд гэрээг ялзруулав, **Малах.** 1–2.

САНВААРЫН ТОМИЛОЛТ.

Томилолт, Томилохыг *үз*

САНВААРЫН ТҮЛХҮҮРҮҮД.

Санваар; Тэргүүн Зөвлөл; Эрин үеийг *мөн үз*

Түлхүүрүүд гэдэг нь Бурханы санваарыг дэлхий дээр удирдан чиглүүлж, хяналт тавихад Бурханаас хүнд өгсөн ерөнхийлөгчийн зөвлөлийн эрхүүд буюу хүч мөн. Санваартнууд ерөнхийлөгчийн зөвлөлийн албан тушаалуудад дуудагдаж, өөрсдөөсөө дээгүүр эрх мэдэл бүхий тэднээс түлхүүрүүдийг хүлээн авдаг. Санваартнууд уг түлхүүрүүдийг атгадаг тэдний тодорхойлсон тэрхүү хязгаарын хүрээнд л санваарыг ашигладаг. Сүмийн ерөнхийлөгч санваарын бүх түлхүүрийг атгадаг (**С ба Г** 107:65–67; 91–92; 132:7).

Петр хаант улсын түлхүүрүүдийг хүлээн авлаа, **Мат.** 16:19. Михаил (Адам) Есүс Христийн удирдлаган дор авралын түлхүүрүүдийг хүлээн авчээ, **С ба Г** 78:16. Хаант улсын түлхүүрүүд ямагт Тэргүүн Зөвлөлд харьяалагддаг, **С ба Г** 81:2. Мелкизе-

дек Санваар Бурханы мэдлэгийн нууцуудын түлхүүрүүдийг атгадаг, **С ба Г 84:19**. Иосеф Смит Оливер Каудери хоёр Израилын цугларалт, Абрахамын сайн мэдээ, түүнчлэн лацдалтын хүчнүүдэд хамаарах түлхүүрүүдийг хүлээн авчээ, **С ба Г 110:11–16**. Арванхоёр Төлөөлөгч тусгай түлхүүрүүдийг атгадаг, **С ба Г 112:16**. Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр нь цаг хугацааны бүрэн байдлын эрин үеийн түлхүүрүүдийг атгадаг, **С ба Г 112:30–34**. Санваартны албан тушаалтнууд түлхүүрүүдийг атгадаг, **С ба Г 124:123**. Түлхүүрүүд байдаг тэр нь мэдлэгийг олох болно, **С ба Г 128:11**. Аароны Санваар нь тохинуулагч тэнгэр элчүүдийн болон наманчлал хийгээд баптисмын түлхүүрүүдийг атгадаг, **ИС—Т 1:69** (С ба Г 13).

САНХЕДРИН. Иудейчүүдийг *мөн үз*

Иудей үндэстний сенат бөгөөд иудейчүүдийн иргэний хийгээд шашны асуудлуудыг шүүх дээд шүүх. Санхедрин нь ерөнхий шүүгч, шуулийн багш нар болон ахлагчдаас сонгож авсан далан нэгэн гишүүнээс бүрддэг байв. Судруудад энэ нь ихэнхдээ зөвлөл хэмээн нэрлэгддэг (Мат. 26:59; Марк 14:55; Үйлс 5:34).

САРА. Абрахамыг *мөн үз*

Хуучин Гэрээнд Абрахамын эхний эхнэр. Өтөл насандаа тэрээр Исаакийн эх болжээ (Эхл. 18:9–15; 21:2).

САРИА. Нифайн эцэг Лихайг *мөн үз*

Мормоны Номонд Лихайн эхнэр (1 Ниф. 5:1–8; 8:14–16; 18:19) мөн Лемен, Лемүел, Сам, Нифай, Иаков, Иосеф түүнчлэн охидынх нь эх (1 Ниф. 2:5; 2 Ниф. 5:6).

САТАН. Чөтгөрийг *үз*

САУЛ, ИЗРАИЛЫН ХААН

Хуучин Гэрээнд Израилыг хуваагдахаас өмнөх анхны хаан. Хэдийгээр

хаанчлалынхаа эхэн үед зөв шударга байсан боловч, эцэстээ тэрээр бардам болж, мөн Бурханд дуулгаваргүй болсон ажээ (1 Сам. 9–31).

СЕЛЕСТИЕЛ АЛДАР СУУ. Алдар суугийн зэрэглэлүүд; Мөнх амьдрал; Өргөмжлөлийг *мөн үз*

Энэ амьдралын дараа хүмүүний очиж болох алдар суугийн гурван зэрэглэлийн хамгийн дээд нь юм. Энд Бурхан Эцэг, түүний Хүү Есүс Христийн дэргэд зөв шударга хүмүүс амьдрах болно.

Селестиелийн алдар суу нь нэг, **1 Кор. 15:40** (С ба Г 76:96). Паул гурав дахь тэнгэрт аваачигджээ, **2 Кор. 12:2**. Үзэгдэлд Селестиел алдар суу үзүүлэгджээ, **С ба Г 76:50–70**. Хэрэв Гэгээнтнүүд Селестиел дэлхийд байрыг хүсэх аваас, тэд бэлтгэх ёстой, **С ба Г 78:7**. Селестиел хаант улсын хуулийг тэсвэрлээгүй тэд Селестиел алдар суунд оршиж чадахгүй, **С ба Г 88:15–22**. Селестиел алдар сууд гурван тэнгэр байдаг; хамгийн дээдхийг нь олж авах дэг жаяг бий болгогдов, **С ба Г 131:1–2**. Хариуцлагын насанд хүрэхээсээ өмнө нас барсан хүүхдүүд Селестиел хаант улсад аврагддаг, **С ба Г 137:10**.

САУЛ, ТАРСЫН. Паулыг *үз*

СЕТ. Адамыг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Адам Ева хоёрын зөв шударга хүү.

Сет төгс хүн байсан бөгөөд түүний төрх эцгийнх нь төрхтэй адил байв, **С ба Г 107:42–43** (Эхл. 5:3). Сүнсний дэлхийд Сет хүчтэнгүүдийн дунд байв, **С ба Г 138:40**. Бурхан өөрийгөө Сетэд илчлэв, **Моце 6:1–3, 8–14**.

СИМЕОН. Израил; Исаакийн хүү Иаковыг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Иаков, түүний эхнэр Леа хоёрын хоёр дахь хүү (Эхл. 29:33; 35:23; Ег. 1:2). Тэрээр Левитэй хамтран шехемчүүдийг устгажээ (Эхл. 34:25–31). Симооны

талаарх Иаковын бошиглол Эхлэл 49:5–7-д байдаг.

Симеоны овог: Симеоны удам угсаа ихэнхдээ Иудагийн овогтой хамт Иудагийн хаант улсын хил дотор амьдарч байв (Иош. 19:1–9; Шаст. дээд 4:24–33). Симеоны овог Канааны эсрэг дайнд Иудатай нэгджээ (Шүүгч. 1:3, 17). Тэрчлэн тэд хожим нь Давидын их цэрэгтэй нэгдсэн билээ (Шаст. дээд 12:25).

СИМОН, КАНААН ХҮН

Шинэ Гэрээнд, Есүс Христийн анхны Арванхоёр Төлөөлөгчийн нэг (Мат. 10:2–4).

СИМОН ПЕТР. Петрийг үз

СИНАГОГ. Иудейчүүдийг мөн үз

Шашны зорилгоор ашигладаг цуглааны газар. Шинэ Гэрээний үед, тавилга хогшил нь ерөнхийдөө энгийн, хууль болон бусад ариун хуйлмал бичээсүүдийг агуулсан авдар, уншлагын ширээ, мөн бишрэн шүтэгчдэд зориулсан сандлуудаас бүрддэг байв.

Синагог бүрийг орон нутгийн ахлагчдын зөвлөл удирддаг байжээ. Хэн орохоор зөвшөөрөгдөх ёстой хийгээд хэн хасагдах ёстойг тэд шийддэг байв (Иохан 9:22; 12:42). Хамгийн чухал албан тушаалтан нь синагогийн захирагч байв (Лук 13:14; Марк 5:22). Тэрээр ерөнхийдөө байшинд анхаарал тавьж, харж хандах мөн үйлчлэлийг хянах ёстой хуулийн багш байв. Үйлчлэгч нь бичиг хэргийн үүргүүдийг гүйцэтгэдэг байв (Лук 4:20).

Иудейчүүд амьдарч байсан Палестин болон бусад аль ч газарт хот болгонд синагог байв. Анхны номлогчид ихэвчлэн синагогуудад үг хэлж болдог байсан учраас энэ нь Есүс Христийн сайн мэдээг дэлгэрүүлэхэд чухал дэмжлэг болдог байв (Үйлс 13:5, 14; 14:1; 17:1, 10; 18:4). Үүний нэгэн адил заншил Мормоны Номон дахь номлогчдын дунд (Алма 16:13; 21:4–5; 32:1) түүнчлэн

энэ эрин үеийн анхны номлогчдын дунд байжээ (С ба Г 66:7; 68:1).

СИНАЙ УУЛ. Мосе; Мосегийн хуулийг мөн үз

Египетээс гарсныхаа дараа Мосе болон израилчууд гурван сар ойролцоо нь буудалласан Синайн хойг дээрх уул; үүнийг бас Хороб Уул хэмээн нэрлэдэг (Ег. 3:1). Энд Бурхан Израилын угсаанд зориулж Мосед өөрийнхөө хуулийг өгчээ; энд мөн асар баригдсан ажээ (Ег. 19:2; 20:18; 24:12; 32:15).

СИОН. Енох; Шинэ Иерусалимыг мөн үз

Сэтгэл зүрхээрээ цэвэр ариун хүмүүс (С ба Г 97:21). Сион гэдэг нь тэрчлэн сэтгэл зүрхээрээ ариун хүмүүс амьдардаг газар гэсэн утгатай. Хотыг Енох болон түүний хүмүүс барьсан бөгөөд зөв шударгынхаа учир Сион хэмээн нэрлэгдсэн уг хот эцэст нь тэнгэрт аваачигджээ (С ба Г 38:4; Мосе 7:18–21; 69). Хожмын өдрүүдэд Сион нэртэй хот нь израилын овог цугларах Миссурийн (Америкийн Нэгдсэн Улс) Жаксон гүнлэгийн ойролцоо баригдах болно (С ба Г 103:11–22; 133:18). Дэлхийн хаана ч амьдарч байсан тэндээ Сионыг барихыг Гэгээнтнүүдэд зөвлөжээ.

Давидын хот Сион хэмээн нэрлэгддэг байв, **Хаад.** дээд 8:1. Сионоос хууль гарах болно, **Иса.** 2:2–3 (Мика 4:2; 2 Ниф. 12:2–3). Гэтэлгэгч Сионд ирэх болно, **Иса.** 59:20. Би та нарыг хотоос нэгийг, ургаас хоёрыг Сионд авчирна, **Иер.** 3:14. Сионы ууланд болон Иерусалимд амь мултрах хүмүүс байх болно, **Иоел** 2:32 (Обад. 1:17). Миний Сионыг байгуулахыг тэр өдөр эрэлхийлэх тэд ивээгдсэн болой, **1 Ниф.** 13:37. Сионы охид ихэмсэг байна, **2 Ниф.** 13:16 (Иса. 3:16). Сионд сэрэмжгүй байх түүнд халаг, **2 Ниф.** 28:19–25. Сионы зорилгыг урагш авчирч мөн байгуулахыг эрэлхийл, **С ба Г** 6:6 (С ба Г 11:6). Сайн сайхны төлөө хүчирлэг хүч чадалд Сионы зарчмыг хөдөлгөхийн

тулд би түүнд бурханлигаар нөлөөлсөн билээ, **С ба Г** 21:7. Шинэ Иерусалим нь Сионы хот хэмээн нэрлэгдэх болно, **С ба Г** 45:66–67. Миссурийн Индепенденс нь Сионы хотын газар болой, **С ба Г** 57:1–3. Сионы хүүхдүүд наманчлах хүртэл тэдний дээр гай зовлон хэвээр байх болно, **С ба Г** 84:58. Тэд нэг зүрх сэтгэл нэг оюунтай учраас Их Эзэн өөрийнхөө хүмүүсийг Сион хэмээн нэрлэдэг, **Мосе** 7:18–19. Сион (Шинэ Иерусалим) Америк тивд баригдах болно, **ИТ** 1:10.

СМИТ, ЛЮСИ МАК. Ахмад;

Смит Иосеф Бага; Иосеф Смитийг *мөн үз*

Бошиглогч Иосеф Смитийн эх, Ахмад Иосеф Смитийн эхнэр (ИС—Т 1:4, 7, 20). Тэрээр 1776 оны долдугаар сарын 8-нд төрж, 1856 оны тавдугаар сарын 5-нд нас баржээ.

Иосеф ээжийгээ Селестиел хаант улсад харжээ, **С ба Г** 137:5.

СМИТ, САМУЕЛ. Х. Бага Иосеф

Смитийг *мөн үз*

Бошиглогч Иосеф Смитийн дүү (ИС—Т 1:4). Самуел 1808 онд төрж, 1844 онд нас баржээ. Тэрээр Мормоны Номны найман гэрчийн нэг байсан бөгөөд сэргээгдсэн Сүмийн анхны номлогч нарын нэгнээр үйлчилжээ (**С ба Г** 23:4; 52:30; 61:33–35; 66:7–8; 75:13).

СМИТ, ХАЙРУМ. Бага Иосеф

Смитийг *мөн үз*

Иосеф Смитийн ах хийгээд түүний итгэлтэй хамтран зүтгэгч. Хайрум 1800 оны Хоёрдугаар сарын 9-нд төржээ. Тэрээр Сүмийн ерөнхийлөгчийн зөвлөлд Иосефын туслахаар үйлчилсэн төдийгүй Сүмийн хоёрдахь патриарх байв. 1844 оны зургадугаар сарын 27-нд тэрээр Иосефын хамт Картейж Шоронд алагджээ.

Бурхан түүний дүү Иосефоор дамжуулан Хайрумд зааварчилгааг илчилжээ, **С ба Г** 11; 23:3. Зүрх сэт-

гэлийнх нь үнэнч шударгын учир адислагдсан болой, миний үйлчлэгч Хайрум Смит, **С ба Г** 124:15. Сүмийн патриархын албыг авахаар Хайрум зарлигдуулав, **С ба Г** 124:91–96, 124. Иосеф, Хайрум хоёр Картейжийн шоронд алагдав, **С ба Г** 135. Хайрум болон бусад сонгосон сүнснүүд цагийн бүрэн байдалд урагш авчрагдахаар хадгалагдсан болой, **С ба Г** 138:53.

СМИТ, ЭММА ХЭЙЛ. Бага Иосеф Смитыг *мөн үз*

Бошиглогч Иосеф Смитийн эхнэр. Сүмийн дууллуудын цуглуулга хийхийг Их Эзэн Эммад зарлиглажээ. Тэрчлэн тэрээр Халамжийн Нийгэмлэгийн анхны ерөнхийлөгчөөр үйлчилж байв.

Их Эзэний тааллын талаарх илчлэлт Эмма Смитэд өгөгдөв, **С ба Г** 25. Гэрлэлтийн талаар Их Эзэн Эмма Смитэд зөвлөгөө өгөв, **С ба Г** 132:51–56.

СОГТУУРУУЛАХ УНДАА

УУХ, СОГТОХ. Мэргэн Ухааны Үгийг *үз*

СОДОМ. Гоморраг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Их Эзэний устгасан ёс бус хот (Эхл. 19:12–29).

СОЛОМОН. Батшеба; Давидыг *мөн үз*

Хуучин Гэрээнд, Давид Батшеба хоёрын хүү (2 Сам. 12:24). Соломон хэсэг хугацаанд Израилын хаан байв.

Давид Соломоныг хаан хэмээн зарлав, **Хаад. дээд** 1:11–53. Их Эзэний замуудаар алхахыг Давид Соломонд үүрэг болгожээ, **Хаад. дээд** 2:1–9. Их Эзэн түүнд ойлгох зүрх сэтгэлийг амлав, **Хаад. дээд** 3:5–15. Хоёр эхийг шүүж, хүүхдийг жинхэнэ эхэд нь олж өгчээ, **Хаад. дээд** 3:16–28. Сургаалт үгс хийгээд дуунуудыг хэлэв, **Хаад. дээд** 4:32. Ариун Сүм барьжээ, **Хаад. дээд** 6; 7:13–51. Ариун Сүмийг онцгойлон адислав, **Хаад. дээд** 8. Шибанийн хатан хаан ирж уулзав,

Хаад, дээд 10:1–13. Соломон Израилын гаднаас гэрлэж, түүний эхнэрүүд зүрх сэтгэлийг нь хуурамч бурхдыг шүтэн бишрэхэд эргүүлэв, **Хаад, дээд** 11:1–8. Их Эзэн Соломонд ууртай байв, **Хаад, дээд** 11:9–13. Нас барав, **Хаад, дээд** 11:43. Давид Соломоны хаанчлалын алдар сууг бошиглов, **Дуул. 72**. Соломон олон эхнэр болон татвар эмс хүлээн авсан боловч зарим нь Их Эзэнээс бус байв, **С ба Г** 132:38 (Иаков 2:24).

СОЛОМОНЫ ДУУН

Хуучин Гэрээний нэг ном. Соломоны Дуулал бол бурханлигаар нөлөөлөгдсөн бичээс биш хэмээн Бошиглогч Иосеф Смит хэлжээ.

СОЛОНГО. Библийн патриарх

Ноа; Ноагийн үе дэх үер;

Хөвөгч авдрыг *мөн үз*

Бурханаас Ноатай байгуулсан гэрээний тэмдэг буюу дохио (Эхл. 9:13–17). ИСО, Эхлэл 9:21–25 нь уг гэрээ дэлхий дахиад хэзээ ч усны үерт бүрхэгдэхгүй, Енохын Сион буцаж ирэх болно, түүнчлэн Их Эзэн дэлхий дээр оршин суухаар дахин ирэх болно хэмээх амлалтуудыг агуулдаг.

СОНГОЛТ. Сонгогдогсод,

Сонгосон; Сонгох, Сонгох эрхийг үз

СОНГОХ ЭРХ. Хариуцлага,

Хариуцлагатай, Хариуцах; Чөлөөт, Эрх чөлөөг *мөн үз*

Өөрсдийнхөө төлөө сонгох мөн үйлдэхээр хүмүүнд өгөгдсөн онцгой боломж хийгээд чадвар.

Бүх модноос чөлөөтэйгөөр идэж болно, **Эхл. 2:16**. Уруу татагдсан байхаас бусдаар хүн өөрийнхөө төлөө үйлдэж чадахгүй, **2 Ниф. 2:15–16**. Хүн эрх чөлөө болон мөнх амьдрал эсвээс боолчлол ба үхлийг сонгох эрхтэй, **2 Ниф. 2:27**. Та нар чөлөөтэй; та нар өөрсдийнхөө төлөө үйлдэхээр зөвшөөрөгдсөн, **Хил. 14:30**. Тэдний эрх чөлөөний учир тэнгэрийн гуравны нэг хэсгийг тэ-

рээр урвуулсан, **С ба Г** 29:36. Чөтгөр хүмүүний үрсийг уруу татах ёстой нь шаардлагатай бөгөөд эс бөгөөс тэд сонгогч байж чадахгүй, **С ба Г** 29:39. Хүн бүр өөрийнхөө төлөө сонгог, **С ба Г** 37:4. Хүн бүр түүнд миний өгсөн ёс суртахууныхаа эрх чөлөөний дагуу үйлдэж болох бөлгөө, **С ба Г** 101:78. Сатан хүмүүний эрх чөлөөг устгахыг эрэлхийлдэг байв, **Моце** 4:3. Их Эзэн хүмүүнд эрх чөлөөг өгсөн билээ, **Моце** 7:32.

СОНГОГДОГСОД, СОНГОГДСОН ХҮМҮҮС

Сонгогдогсод нь Бурханыг бүх зүрх сэтгэлээрээ хайрладаг мөн түүний таалалд нийцэх амьдралаар амьдардаг хүмүүс юм. Шавь ёсны ийм амьдарлаар амьдардаг хүмүүс нэгэн цагт Их Эзэнээр түүний сонгосон хүүхдүүдийн дунд шилэгдэх болно.

Хэрэв боломжтой байх аваас, тэд сонгогдогсдыг хуртэл төөрөлдүүлэх болно, **Мат. 24:24**. Сонгогдсон эзэгтэйн хүүхдүүд үнэнч хийгээд итгэлтэй байсан учраас Иохан баяртай байв, **2 Иохан 1**. Чиний гэм нүгэл өршөөгдсөн, мөн чи сонгогдсон хатагтай болой, **С ба Г** 29:7. Миний сонгосон хүмүүс миний дуу хоолойг сонсож, зүрх сэтгэлээ хатууруулах нь үгүй, **С ба Г** 29:7. Бүр би дэлхийн дөрвөн зүгээс өөрийн сонгосон хүмүүсийг цуглуулах болно, **С ба Г** 33:6. Судрууд миний өөрийн сонгосон хүмүүсийн авралын тулд өгөгддөг, **С ба Г** 35:20–21. Санваарын дуудлагаа эрхэмлэн биелүүлдэг тэд Бурханы сонгосон хүмүүс болдог, **С ба Г** 84:33–34. Сонгосон хүмүүсийн тусын тулд өс хонзонгийн өдрүүд богиносгогдох болно, **ИС—Мат. 1:20**.

СОНГОГДОГСОД, СОНГОГДСОН ХҮМҮҮС.

Дуудлага ба Сонголтыг *мөн үз*

Мөнх бус амьдралд зохистой байхад тулгуурлан Абрахамын үр удам мөн Израилын угсааных байхаар мөн гэрээт хүмүүс болгохоор Бурха-

ны сонгосон хүмүүс билээ (Дэд хууль 32:7–9; Абр. 2:9–11). Тэд дэлхийн бүх үндэстнүүдийг адисалж болохын тулд эдгээр хүмүүст онцгой адислал болон үүргүүд өгөгдсөн билээ (Ром 11:5–7; 1 Петр 1:2; Алма 13:1–5; С ба Г 84:99). Хэдий тийм ч, бүр эдгээр сонгогдсон хүмүүс авралыг олж авахын тулд энэ амьдралд дуудагдаж мөн сонгогдох ёстой.

СОНГОГДСОН, СОНГОГДОГСОД (ТЭМДЭГ НЭР БУЮУ НЭР ҮГ). Дуудах,

Бурханаас дуудагдсан,
Дуудлагыг мөн үз

Тусгай үүрэг хариуцлагуудын тулд Бурханаар шилэгдэгсэд.

Би өөрийн сонгосон нэгэнтэй гэрээ байгуулсан, **Дуул.** 89:3. Олон нь дуудагдсан боловч цөөхөн нь сонгогдсон, **Мат.** 22:14 (Мат 20:16; С ба Г 95:5; 121:34, 40). Гэгээнтнүүд сонгогдсон угсаа, хаант тахилч нар юм, **1 Петр** 2:9. Христ Бурханы Хайрт мөн эхлэлээс Сонгогдсон Нэгэн байсан, **Моце** 4:2.

СОНГОХ, СОНГОСОН,

СОНГОГДСОН. Сонгох эрх;
Дуудах, Бурханаас дуудагдсан,
Дуудлага; Чөлөөт, Эрх чөлөөг
мөн үз

Бие хүн болон бүлэг хүмүүсийг Их Эзэн шилэх буюу сонгохдоо тэрээр ихэвчлэн тэднийг үйлчлүүлэхээр дууддаг.

Хэнд үйлчлэх вэ гэдгээ та нар өнөөдөр сонго, **Иош.** 24:15 (Алма 30:8; Моце 6:33). Би чамайг зовлонгийн зууханд сонгосон, **Иса.** 48:10 (1 Ниф. 20:10). Та нар намайг сонгоогүй, харин би та нарыг сонгосон, **Иохан** 15:16. Бурхан мэргэдийг ичээхийн тулд ертөнцийн мунхаг юмсыг сонгожээ, **1 Кор.** 1:27. Тэрээр биднийг ертөнцийн сууринаас өмнө сонгосон, **Ефес** 1:4. Бид эрх чөлөө болон мөнх амьдрал, эсвээс боолчлол болон үхлийг сонгох эрхтэй, **2 Ниф.** 2:27. Хүнлэг хийгээд агуу хүмүүс эхлэлд сонгогдсон болой, **С ба Г** 138:55–

56. Израил Бурханаас сонгогдсон буюу, **Моце** 1:26. Абрахам төрөхөөсөө өмнө сонгогдсон бөлгөө, **Абр.** 3:23.

СӨНӨСӨН ТЭНГИС

Иорданы Хөндийн өмнөд хязгаар дахь давст тэнгис. Үүнийг мөн Давст тэнгис гэдэг байв. Үүний гадаргуу нь Газрын дундад тэнгисээс ойролцоогоор 1300 фут (395 метр) доор байдаг. Үүний эргийн ойролцоо Содом, Гоморра болон Зоар буюу Бела хотууд байдаг байв (Эхл. 14:2–3).

Бошиглолын биелэлт болон Аврагчийн хоёр дахь ирэлтийн нэг тэмдэг нь Сөнөсөн тэнгис эрүүлжигдэж мөн тэнд амьдрал цэцэглэх болно (Езек. 47:8–9).

СТЕФЕН

Стефен бол Шинэ Гэрээний үед Аврагч хийгээд түүний Сүмийн төлөө амь насаа алдагч байв. Түүний номлол Стефенийг Санхедрины өмнө өөрийгөө хамгаалахад тэнд байлцсан Паулын агуу ажлыг урьдчилан тодорхойлж, нөлөөлсөн бололтой.

Стефен бол Арванхоёр Төлөөлөгчид туслахаар томилогдсон долоогийн нэг нь байв, **Үйлс** 6:1–8. Стефен агуу гайхалтай зүйлс хийгээд гайхамшгуудыг үйлджээ, **Үйлс** 6:8. Стефен иудейчүүдтэй маргаанаар холбогджээ, **Үйлс** 6:9–10. Түүний эсрэг ял тулгаж тэрээр Санхедрины өмнө соригдов, **Үйлс** 6:11–15. Стефен өөрийн хамгаалалтыг танилцуулав, **Үйлс** 7:2–53. Тэрээр Ариун Сүнсээр дүүрэн байж Эцэг Хүү хоёрыг үзэгдэлд харав, **Үйлс** 7:55–56. Стефен гэрчлэлийнхээ учир алагджээ, **Үйлс** 7:54–60.

СУДРУУД. Агуу Үнэт Сувд;

Бурханы үг; Библи; Канон;
Мормоны Ном; Он дарааллын
ном; Сургаал ба Гэрээг мөн үз

Ариун Сүнсээр хөтлөгдсөн үедээ Бурханы ариун хүмүүсийн бичсэн буюу ярьсан үгс. Сүмийн албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн суд-

рууд нь өнөөдөр Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувдаас бүрддэг. Есүс болон Шинэ Гэрээг бичигчид Хуучин Гэрээний номнуудыг судар хэмээн үздэг байв (Мат. 22:29; Иохан 5:39; 2 Тим. 3:15; 2 Петр 1:20–21).

Тэр бидэнд судар тайлбарлаж байхад бидний зүрх шатаж байсан бус уу, **Лук** 24:32. Судруудыг судал; учир нь тэдгээр дотор мөнх амь бий хэмээн та нар боддог. Тэдгээр нь намайг гэрчилдэг, **Иохан** 5:39. Христийн үг та нарт юу хийх ёстойг чинь хэлэх болно, **2 Ниф.** 32:3. Ариун судруудад итгэхээр удирдагдсан болгон нь итгэлдээ чанд гуйвшгүй болгогдсон байв, **Хил.** 15:7–8. Хүмүүн судруудтай тэмцэлдэж мөн тэдгээрийг ойлгох нь үгүй, **С ба Г** 10:63. Эдгээр үгс нь хүмүүнээс бус, хүмүүсээс бус харин надаас билээ, **С ба Г** 18:34–36. Мормоны Ном урагш гарч ирснээр дэлхийд судрууд үнэн гэдгийг баталдаг, **С ба Г** 20:2, 8–12. Чиний цаг хугацаа судруудаас суралцахад зориулагдах, **С ба Г** 26:1. Судрууд нь Гэгээнтнүүдэд заавар болон өгөгддөг, **С ба Г** 33:16. Судрууд нь сонгогдогсдын авралын төлөө өгөгдсөн болой, **С ба Г** 35:20. Библи хийгээд Мормоны Номон дахь миний сайн мэдээний зарчмуудыг заа, **С ба Г** 42:12. Эдгээр зүйлүүдийн талаарх миний хуулиуд миний судруудад өгөгдсөн бөлгөө, **С ба Г** 42:28. Ариун Сүнсний нөлөөлөл дор яригдах ямар ч зүйл бол судар болой, **С ба Г** 68:4.

Алдагдсан судрууд: Өнөөдөр бидэнд байхгүй олон ариун нандин бичээсүүд судруудад дурдагдсан байдаг тэдгээрийн дотор доорх номнууд болон зохиогчид байдаг; үүнд: Гэрээ (Ег. 24:7), Их Эзэний дайнүүд (Тоол. 21:14), Иашер (Иош. 10:13; 2 Сам. 1:18), Соломоны үйлс (Хаад. дээд 11:41), үзмэрч Самуел (Шаст. дээд 29:29), Бошиглогч Натан (Шаст. дэд 9:29), бошиглогч Шемаиа болон (Шаст. дэд 12:15), бошиглогч Иддо

(Шаст. дэд 13:22), Иеху (Шаст. дэд 20:34), үзмэрчдийн айлдварууд (Шаст. дэд 33:19), Енох (Иуда 1:14), мөн Зенокийн, Неум, Зеносын үгс (1 Ниф. 19:10), Зенос (Иаков 5:1), Зенок болон Езиас (Хил. 8:20), мөн дурсамжийн ном (Мосе 6:5); түүнчлэн коринтчуудад хийгээд ефесчүүдэд бичсэн захидлууд (1 Коринт 5:9), мөн (Ефес 3:3), Лаодикаас бичсэн захидлууд (Кол. 4:16).

Судрууд хадгалагдах болно: Бошиглогчдын хэлсэн үгсийг бид хадгалж болохын тулд бид эдгээр цэдгүүдийг олж авах ёстой, **1 Ниф.** 3:19–20. Би эдгээр ялтсуудыг хадгалах ёстой, **Иаков** 1:3. Эдгээр зүйлс нь Бурханы мутраар хадгалагдаж мөн хамгаалагдаж ирсэн билээ, **Моз.** 1:5. Эдгээр нандин зүйлсэд санаа тавь, **Алма** 37:47. Эдгээр судрууд аюулгүй газар хадгалагдах болно, **С ба Г** 42:56. Тэдгээрийг хадгалахын тулд бүх зүйлсээ ашигла, **ИС—Т** 1:59.

Судруудын үнэ цэнэ: Чи бүх Израилын өмнө энэ хуулийг унших ёстой, **Дэд хууль** 31:10–13. Энэ хуулийн номыг амнаасаа бүү салга, **Иош.** 1:8. Их Эзэний хууль нь төгс, сэтгэлийг сэргээдэг, **Дуул.** 19:7. Таны үг бол миний хөл дэх дэнлүү, **Дуул.** 119:105. Судрууд намайг гэрчилдэг, **Иохан** 5:39. Бүх судрууд Бурханы онгодоор өгөгддөг хийгээд сургаалууд ба удирдамжаар батлагддаг, **2 Тим.** 3:15–16. Бидэнд эрдэм болон тус байж болохын тулд би бүхий л судруудыг өөрсөдтэйгөө адилтгасан билээ, **1 Ниф.** 19:23. Миний зүрх сэтгэл судруудад баясдаг, **2 Ниф.** 4:15–16. Бид Христэд итгэхийг хүүхдүүддээ мөн түүнчлэн өөрсдийн ах дүүст ятгахын тулд хичээнгүйлэн хөдөлмөрлөдөг, **2 Ниф.** 25:23. Тэд судруудыг судалж, мөн ёс бус хүний үгсийг дахин сонссонгүй, **Иаков** 7:23 (Алма 14:1). Хэрэв эдгээр ялтсууд байхгүй байсан аваас бид мэдэхгүйдээ зовох ёстой, **Моз.** 1:2–7. Бурханы үгийг мэдэж болохын тулд тэд судруудыг

хичээнгүйлэн судалсан байв, **Алма** 17:2–3. Судрууд хүмүүсийг авралд авчрахаар хадгалагддаг, **Алма** 37:1–19 (2 Ниф. 3:15). Бурханы үг хүмүүнийг Христ уруу хөтөлдөг, **Хил.** 3:29. Тэд Ариун Сүнсээр юуг ч ярьсан тэр нь судар, мөн авралд хүргэх Бурханы хүч байх болно, **С ба Г** 68:4. Миний Сүмийг барих хийгээд миний хүмүүсийг бэлтгэх зорилгын тулд миний бүрэн судрыг хэвлэ, **С ба Г** 104:58–59. Миний үгсийг нандигнасан хэн ч хууртагдах нь үгүй, **ИС—Мат.** 1:37.

Судрууд урагш гарч ирнэ хэмээн бошиглогдсон нь: Исаиа Мормоны Номыг урагш гарч ирэхийг урьдчилан хэлсэн билээ, **Иса.** 29:11–14. Нэг савааг ав, тэгээд үүн дээрээ бич, Иудагийн төлөө, **Езек** 37:15–20. Өөр номнууд урагш гарч ирэх болно, **1 Ниф.** 13:39. Библи миний бүх үгсийг агуулдаг хэмээн та нар бодох хэрэггүй, **2 Ниф.** 29:10–14. Урагш гарч ирэх тэрхүү цэдгээр та нарын өмнө тавигдах Христийн сайн мэдээнээс баригтун, **Морм.** 7:8–9. Энэ зүйлүүдийг гэрэлд авчрах тэрээр адислагдсан болой, **Морм.** 8:16. Эдгээр зүйлүүдийг бич мөнт бибээр тэдэнд өөрийнхөө зохих цагт үзүүлэх болно, **Ифер** 3:27 (Ифер 4:7). Тэрээр олон зүйлийг илрүүлээгүй гэдэгт бид итгэдэг, **ИТ** 1:9.

СУДРЫН АЛГА БОЛСОН НОМНУУД. Судрууд—Алга болсон судруудыг үз

СУЛ ДОРОЙ БАЙДАЛ. Даруу, Даруу байдлыг мөн үз

Мөнх бус хийгээд чадвар, хүч буюу ур чадвар дутмаг байх нөхцөл. Сул дорой нь биеийн шинж юм. Бүх хүмүүс сул дорой байдаг бөгөөд зөвхөн Бурханы ач ивээлээр тэд зөв шударга үйлс хийх хүчийг хүлээн авдаг (Иаков 4:6–7). Энэ сул дорой байдал нь хүн бүрд байдаг хувь хүний сул дорой байдал буюу сул талын илэрлийн нэг хэсэг юм.

Сул дорой гарнуудыг хүчтэй болго,

Иса. 35:3–4. Сүнс хүсч байна, харин махан бие сул дорой юм, **Мат.** 26:41 (Марк 14:38). Маханбодид оршсоны дагуу өөрт буй дутагдлаас хэмээн өөрийгөө би зөвтгөнө, **1 Ниф.** 19:6. Би сул дорой хэдий ч эдгээр зүйлүүдийг бичихийг зарлигдуулсан билээ, **2 Ниф.** 33:11. Сул доройгоос нь болоод зарцдаа бүү хилэгнэгтүн, **Ифер** 3:2. Бидний бичгийн сул дорой байдлын улмаас, харийнхан эдгээр зүйлийг элэлгэх болно, **Ифер** 12:23–25, 40. Би тэдэнд өөрсдийнх нь сул доройг үзүүлэх болно, **Ифер** 12:27–28. Чи өөрийн сул доройг харсны учир, чи хүчирхэг болгогдох болно, **Ифер** 12:37. Та нарын дундах сул доройчууд нь үүнээс хойш хүчтэй болгогдох болно, **С ба Г** 50:16. Есүс Христ хүмүүний сул доройг мэддэг болой, **С ба Г** 62:1.

СУРГААЛ БА ГЭРЭЭ. Бага Иосеф Смит; Зарлигуудын ном; Канон; Судруудыг мөн үз

Хожмын үеийн бурханлиг илчлэлтүүд болон сүнсээр өдөөгдсөн тунхгуудын түүвэр. Хожмын өдрүүдэд дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулах болон зохицуулахын тулд Их Эзэн эдгээрийг Иосеф Смит болон түүний хэд хэдэн залгамжлагчид өгсөн билээ. Сургаал ба Гэрээ бол Библи, Мормоны Ном, мөн Агуу Үнэт Сувдын хамт Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн жишиг бүтээлүүдийн нэг юм. Сургаал ба Гэрээ бол хосгүй өвөрмөц юм; өнөө үед өөрийн хаант улсыг дахин сэргээхийн тулд Их Эзэн эдгээр илчлэлтүүдийг сонгосон бошиглогчиддоо өгчээ. Илчлэлтэд Их Эзэн Есүс Христийн намуухан атлаа хүчтэй дуу хоолойг хүн сонсдог (С ба Г 18:35–36).

Сургаал ба Гэрээ нь хожмын өдрүүд дэх Сүмийн суурь бөгөөд дэлхийд ашиг тустай хэмээн Бошиглогч Иосеф Смит хэлжээ (С ба Г 70, толгой гарчиг). Илчлэлт нь Их Эзэний хоёр дахь ирэлтийн замыг бэлтгэхээр үүсгэгдсэн ажил, дэлхийн

эхлэлээс хойших бүх ариун бошиглогчдоор хэлэгдсэн үгсийн биелэлт бөлгөө.

СУРГААЛТ ЗҮЙРЛЭЛ. Сайн
Мэдээ—Сайн Мэдээнүүдийн
зохицлыг мөн үз

Сүнсний үнэнийг буюу зарчмыг дүрслэн харуулах буюу заахад ашигладаг энгийн түүх. Сургаалт зүйрлэл нь ердийн зүйл буюу үйл явдлыг жишиж харьцуулах явдал дээр үндэслэгдсэн байдаг бөгөөд уг сургаалт зүйрлэлийн цаад утга учир нь сүнслэг байдлын хувьд үүнийг хүлээн авахад бэлтгэгдээгүй сонсогчдод учир битүүлэг байх нь олонтаа байдаг (Мат. 13:10–17).

Есүс сургаалт зүйрлэлээр олон-таа заадаг байлаа. Түүний үндсэн гол сургаалт зүйрлэлийн жагсаалтыг “Сайн Мэдээнүүдээс” үз.

СУРГААЛТ ҮГС

Ёс суртахууны товч зүйр цэцэн хэллэг буюу зөвлөгөө.

Сургаалт үгсийн ном: Олон сургаалт зүйрлэл, зүйр цэцэн хэллэг түүнчлэн Соломоны бичсэн зарим яруу найргийг агуулсан, Хуучин Гэрээний нэг ном. Сургаалт үгсийн номноос Шинэ Гэрээнд олонтаа иш татсан байдаг.

Бүлэг 1–9 нь жинхэнэ мэргэн ухааны тухай тайлбарыг агуулдаг. Бүлэг 10–24 нь амьдралын зөв болон буруу хэв маягийн тухай зүйр цэцэн хэллэгүүдийн цуглуулгыг агуулдаг. Бүлэг 25–29 нь Иудагийн хаан Хезекиагийн хүмүүсийн тухай Соломоны цэдэглэсэн сургаалт үгсийг агуулдаг. Бүлэг 30–31 нь ариун журамт эмэгтэйн тухай зураглалыг агуулдаг.

СУУРИЙН ЧУЛУУ, БУЛАНГИЙН ТУЛГУУР

ЧУЛУУ. Есүс Христийг мөн үз

Барилгын суурийн буланг бий болгодог гол чулуу. Есүс Христ тулгуурын чулуу хэмээн нэрлэгддэг (Ефес 2:20).

Барилгачдын голсон чулуу булангийн тулгуур чулуу болно, **Дуул.** 118:22 (Мат. 21:42–44; Марк 12:10; Лук 20:17; Үйлс 4:10–12). Иудейчүүд булангийн чулуунаас татгалзав, **Иаков** 4:15–17.

СҮМИЙН НЭР. Есүс Христийн Сүм; Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм; Мормончуудыг мөн үз

Мормоны Номонд, амилалтынхаа дөнгөж дараахан Есүс Христ зөв шударга нифайчуудад айлчлахдаа, Сүм өөрийнх нь нэрийг авах ёстой хэмээн хэлсэн байдаг (3 Ниф. 27:3–8). Өнөө үед Их Эзэн Сүмийн нэрийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм гэж байхаар илчилжээ (С ба Г 115:4).

**СҮМИЙН УДИРДАГЧДЫГ
ДЭМЖИН БАТЛАХ.** Нийтийн
дэмжлэгийг мөн үз

Сүмийн ерөнхий хийгээд орон нутгийн удирдлагын албан тушаалд үйлчилж буй хүмүүсийг дэмжин батлах.

Иошуаг бүх чуулганы өмнө зогсоогоод мөн тэдний нүдэн дээр түүнд үүрэг хариуцлагыг даатгагтун, **Тоол.** 27:18–19. Бүх хүмүүс баярлан уухайлж, Хаан мандтугай хэмээн хэлэв, **1 Сам.** 10:24. Түүний бошиглогчид итгэ, тэгвэл чи хөгжин болно, **Шаст.** дэд 20:20. Чи захирагдахын тулд тэднийг дага, **Евр.** 13:17. Дургүйцээгүй учир чи Их Эзэний ивээлийг хүртэх болно, **1 Ниф.** 3:6. Бошиглогчдыг хүлээн авч чулуугаар шидээгүй нь тэд байв, **3 Ниф.** 10:12–13. Энэ арванхоёрын үгэнд анхаарлаа хандуул, **3 Ниф.** 12:1. Миний өөрийн дуу хоолойгоор эсвээс миний үйлчлэгчдийн дуу хоолойгоор байна уу, энэ нь ижил юм, **С ба Г** 1:38. Түүний үгийг миний өөрийн амнаас адил хүлээн авах ёстой, **С ба Г** 21:5. Миний үйлчлэгчдийг хүлээн авдаг тэрээр намайг хүлээн авна, **С ба Г** 84:35–38. Намайг хүлээн

авах тэд миний илгээсэн тэднийг хүлээн авдаг, **С ба Г** 112:20. Хэрэв миний хүмүүс миний томилсон эдгээр хүмүүсийн дуу хоолойг сонсохгүй аваас, тэд адислагдахгүй болой, **С ба Г** 124:45–46.

СҮНС. Амилуулалт; Бодгаль;

Биеийн үхэл; Хүн, Хүмүүсийг мөн үз

Мөнх бус байдлын үед бие махбодид оршдог бөгөөд үхлийн дараа амилуулалт хүртэл салангид биеэр орших мөнх бус төрөлтийн өмнө байсан биеийн амьд хэсэг. Бүх амьд зүйлс—хүн төрөлхтөн, амьтад хийгээд ургамлууд нь дэлхий дээр ямар нэг төрлийн амьдрал оршихоос өмнө сүнс байжээ (Эхл. 2:4–5; Моце 3:4–7). Сүнсэн бие нь яг бие махбодитой адил (1 Ниф. 11:11; Ифер 3:15–16; С ба Г 77:2; С ба Г 129). Сүнс нь матери боловч мөнх бус элемент буюу материас илүү сайхан хийгээд ариун юм (С ба Г 131:7).

Хүн болгон дэлхий дээр мөнх бус эцэг эхэд төрөхөөсөө өмнө Тэнгэрлэг Эцэг Эхэд Сүнсээр төрсөн учраас чухамдаа Бурханы хүү буюу охин юм (Евр. 12:9). Дэлхий дээрх хүн болгон яс, махан биенээс гадна үхэшгүй сүнсэн биетэй байдаг. Зарим үед сударт тодорхойлсноор, сүнс хийгээд бие нь хамтдаа бодгалийг бий болгодог (Эхл. 2:7; С ба Г 88:15; Моце 3:7; 9, 19; Абр. 5:7). Сүнс биегүйгээр амьдарч чадна, харин бие сүнсгүйгээр амьдарч чадахгүй (Иаков 2:26). Биеийн үхэл бол биенээс сүнс салж байгаа явдал мөн. Амилуулалтад сүнс мах болон ясан биетэй дахин нэгдэж мөнх бус хоёр гол чухал ялгарах онцлогтой болдог: эдгээр нь дахин хэзээ ч салахгүй байх болно, түүнчлэн бие нь үхэшгүй хийгээд төгс болгогдох болно (Алма 11:45; С ба Г 138:16–17).

Сүнсэнд та нарын харж байгаа Над шиг яс, мах байдаггүй юм, **Лук** 24:39. Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг Сүнс Өөрөө бидний сүнтэй хамт гэрчилдэг, **Ром** 8:16. Биеэрээ хийгээд сүнсээрээ Бурханыг алдаршуулаг-

тун, **1 Кор.** 6:20. Энэ бие бээр миний сүнсний бие болой, **Ифер** 3:16. Хүн бол сүнс болой, **С ба Г** 93:33. Их Эзэн диваажинд зөв шударга сүнснүүдэд тохинуулсан болой, **С ба Г** 138:28–30 (1 Петр 3:18–19). Та нар усаар мөн цусаар мөн сүнсээр төрсөн юм, **Моце** 6:59. Тэрбээр сүнс байсан тэдний дунд зогсож байв, **Абр.** 3:23.

Муу ёрын сүнснүүд: Есүс олон бузар сүнснүүдийг зайлуулав, **Марк** 1:27, 34, 39. Бузар сүнс чи энэ хүнээс гар, **Марк** 5:2–13. Хилэнцэт сүнс хүнд залбирахыг үл сургана, **2 Ниф.** 32:8. Есүсийн нэрээр чөтгөрүүдийг мөн цэвэр бус сүнснүүдийг зайлуулав, **3 Ниф.** 7:19. Дэлхийг хууран мэхэлж буй олон хуурамч сүнснүүд буй, **С ба Г** 50:2, 31–32. Сүнс нь Бурханаас уу, эсвээс чөтгөрөөс үү гэдгийг ялган таних гурван түлхүүрийг Иосеф Смит тайлбарлав, **С ба Г** 129.

СҮНСНИЙ БҮТЭЭЛТ. Бүтээх,

Бүтээлт; Хүн, Хүмүүсийг мөн үз

Их Эзэн бүх зүйлийг бие махбодитойгоор бүтээхээсээ өмнө сүнслэгээр бүтээжээ (Моце 3:5).

Их Эзэн бүх ургамлуудыг эдгээр нь дэлхий дээр байхаас өмнө хийжээ, **Эхл.** 2:4–6 (Абр. 5:5). Сүнснийхээ хүчээр би бүх зүйлийг бүтээсэн—эхлээд сүнслэг байдлаар, дараа нь материаллагаар, **С ба Г** 29:31–32. Мөн тэр нь сүнслэг тэр зүйлийн адил төстэй байдал дахь зуурдын зүйл бөлгөө; **С ба Г** 77:2. Би дэлхийг бүтээсэн мөн тэднийг маханбодь байхаас өмнө нь хүмүүнийг бий болгосон билээ, **Моце** 6:51.

СҮНСНИЙ БЭЛГҮҮД. Бэлгийг

мөн үз

Өөрсдийнх нь төлөө хийгээд бусдыг адислахад ашиглахын тулд Их Эзэн сүнсний тусгай адислалуудыг зохистой хувь хүмүүст өгсөн байдаг. Сүнсний бэлгүүдийн дүрслэлтийг Сургаал ба Гэрээ 46:11–33, 1 Коринт 12:1–12; Моронай 10:8–18-аас судал.

Үлэмж агуу бэлгүүдийг хүсэн тэ-

мүүлэгтүн, **1 Кор.** 12:31 (1 Кор. 14:1). Нифайчуудад Сүнсний олон бэлгүүд өгөгдсөн байлаа, **Алма** 9:21. Их Эзэн бэлгээр буюу Ариун Сүнсний хүчээр ажиллахаа больсон хэмээн хэлдэг түүнд халаг, **3 Ниф.** 29:6. Бурхан бэлгүүдийг итгэлтнүүдэд өгдөг, **Морм.** 9:7. Бэлгүүд Христийн Сүнсээр ирдэг, **Моро.** 10:17. Олон бэлэг буй бөгөөд хүн болгонд бэлэг нь Сүнсээр өгөгддөг, **С ба Г** 46:11. Сүнсний бэлгүүдийг ялган таних хүч Сүмийн удирдагчдад өгөгдсөн байдаг, **С ба Г** 46:27. Сүмийн Ерөнхийлөгч Бурханы бүх бэлгүүдтэй байдаг, **С ба Г** 107:92.

СҮНСНИЙ ДЭЛХИЙ. Диваажин;
Мөнх бус байдлын өмнөх
амьдрал; Тамыг үз

СҮНСНИЙ ҮХЭЛ. Аврал; Адам
Ева хоёрын Уналт; Мөхлийн
хөвгүүд; Там; Чөтгөр; Ялыг
мөн үз

Бурхан болон түүний нөлөөнөөс салах; зөв шударга байдалд хамаарах зүйлсийн хувьд үхэх. Люсифер болон тэнгэрийн гуравны нэг тэнгэрээс доош хөөгдөхдөө сүнсний үхлээр үхжээ (**С ба Г** 29:36–37).

Адамын уналтаар Сүнсний үхэл дэлхийд иржээ (**Мосе** 6:48). Хилэнцэт санаа бодол, үг хэл хийгээд үйлтэй мөнх бус хүмүүс бүр дэлхий дээр амьд байх үедээ сүнсний хувьд үхсэн байдаг, (**1 Тим.** 5:6). Есүс Христийн цагаатгалаар дамжин мөн сайн мэдээний зарчмууд болон ёслолуудад дуулгавартай байснаар эрэгтэй, эмэгтэй хүмүүс нүглээс ангид байж сүнсний үхлийг ялж чадна.

Мөнх бус биеийн үхлийг даган сүнсний үхэл мөн ирдэг. Амилуулагдсан хүмүүс хийгээд чөтгөр түүнчлэн түүний элчүүд аль аль нь шүүгдэх болно. Сайн Мэдээний гэрэл хийгээд үнэний эсрэг санаатайгаар эсэргүүцсэн хүмүүс сүнсний үхлээр үхэх болно. Энэ үхлийг ихэнхдээ хоёр дахь үхэл хэмээн нэрлэдэг (**Алма** 12:16; **Хил.** 14:16–19; **С ба Г** 76:36–38).

Бузар мууг үйлдэгчид таслагдана, **Дуул.** 37:9. Махан биеийн бодол бол үхэл, **Ром** 8:6 (2 Ниф. 9:39). Хүсэл тачаал нь хүнийг үгүйрэл болон сүйрэлд хүргэдэг, **1 Тим.** 6:9. Нүгэл нь үхлийг авчирдаг, **Иаков** 1:15. Ялагч нь хоёр дахь үхлээр үхэхгүй, **Илч.** 2:11. Иймд нь хоёр дахь үхэл хүчгүй, **Илч.** 20:6, 12–14. Хилэнцтэн нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуурт хувьтай байна, **Илч.** 21:8 (**С ба Г** 63:17–18). Хүн эрх чөлөө болон мөнх амьдрал, эсвээс боолчлол болон үхлийг сонгох эрхтэй, **2 Ниф.** 2:27 (**2 Ниф.** 10:23; **Алма** 29:5; **Хил.** 14:30–31). Үхэл болон тамаас оргох бидний замыг Бурхан бэлтгэсэн юм, **2 Ниф.** 9:10. Хоёр дахь үхлээр үхэхгүйн тулд өөрсдийгөө тамын тарчлалаас салга, **Иаков** 3:11. Эгэл хүн бол Бурханы дайсан, **Моз.** 3:19. Та нар хоёр дахь үхлийг амсаггүйн тулд Их Эзэн та нарт наманчлалыг хайрлаг, **Алма** 13:30. Алма үхлийн үүрдийн гинжээр ороогдсон байв, **Алма** 36:18. Хилэнцтэнүүд зөв шударгад хамаарах зүйлүүдийн хувьд үхмэл билээ, **Алма** 40:26 (**Алма** 12:16). Уналт нь бүх төрөлхтний дээр сүнсний үхлийг авчирсан буюу, **Алма** 42:9 (**Хил.** 14:16–18). Адам унахдаа тэрээр сүнснийхээр үхсэн байв, **С ба Г** 29:40–41, 44.

СҮНСНИЙ ХАРАНХУЙ. Ёс бусыг
үйлдэгч, Ёс бус явдлыг *мөн үз*

Ёс бус явдал буюу сүнсний зүйлүүдийг үл тоомсорлох явдал.

Гэрлийг харанхуйгаар солигч тэдэнд халаг, **Иса.** 5:20 (2 Ниф. 15:20). Газрыг харанхуй бүрхэн, гүн харанхуй хүмүүсийг хучсан, **Иса.** 60:2. Есүс харанхуйд суугчдад гэрлийг өгөх болно, **Лук** 1:79. Гэрэл харанхуйг гийгүүлэхэд харанхуй түүнийг ойлгосонгүй, **Иохан** 1:5 (**С ба Г** 45:7). Харанхуйн үйлсийг хажуу тийш тавьж, гэрлийн зэвсгүүдийг агацаага, **Ром** 13:12. Харанхуйн үр жимсгүй ажлуудад бүү оролц, **Ефес** 5:8–11. Асуугаагүй учраас, та нар гэрэлд авчрагдсангүй, харин харанхуйд мөхөх ёстой,

2 Ниф. 32:4. Сатан харанхуйн ажлуудыг тараадаг, **Хил.** 6:28–31. Дэлхий дээр харанхуйн хүч ноёрхож байна, **С ба Г** 38:8, 11–12. Өвч дэлхий харанхуй болон нүглүүд дор гасалж байна, **С ба Г** 84:49–54. Хэрэв та нар миний сүр жавхлангийн төлөө бүхнээ зориулах аваас, та нар харанхуй байх нь үгүй, **С ба Г** 88:67. Харанхуйн ажлууд бүх хүн төрөлхтний дунд ноёрхож эхэлж байна, **Мосе** 5:55.

СҮНСНИЙ ШОРОН. Тамыг үз

СҮҮЛЧИЙН ЗООГ. Дээгүүр өнгөрсний баяр; Ариун ёслолыг мөн үз

Шинэ Гэрээнд өгүүлснээр Есүс баривчлагдаж цовдлогдохоосоо өмнө идсэн сүүлчийн зоог (Лук 22:14–18). Дээгүүр өнгөрсний баярын үеэр тэр болон түүний Арванхоёр Төлөөлөгч энэхүү хоолыг зоогложээ (**Мат.** 26:17–30; **Марк** 14:12; 18; **Лук** 22:7–13).

Аврагч талх, дарсыг ерөөж, үүнийг Төлөөлөгчдөд өгөв, **Мат.** 26:26–29 (**Марк** 14:22–25; **Лук** 22:7–20). Есүс Төлөөлөгчдийн хөлийг угаав, **Иохан** 13. Иудас Есүсээс урвагч хэмээн нэрлэгдэв, **Иохан** 13:21; 26 (**Мат.** 26:20–25).

СЭРЭМЖЛҮҮЛЭГ,
СЭРЭМЖЛҮҮЛЭХ. Харах,
Харуулуудыг мөн үз

Мэдэгдэл буюу сануулга өгөх. Бошиглогчид, удирдагчид болон эцэг эхчүүд Их Эзэнд болон түүний сургаалуудад дуулгавартай байхыг бусдад зааж мөн сануулдаг.

Иаков төрөл бүрийн гэм нүглүүдийн эсрэг байхыг Нифайн хүмүүст сануулжээ, **Иаков** 3:12. Сануулгын дуу хоолой нь бүх хүмүүст зориулагдсан бөлгөө, **С ба Г** 1:4. Номлол чинь сэрэмжлүүлгийн дуу хоолой байг, **С ба Г** 38:41. Өнөөдөр бол сэрэмжлүүлгийн өдөр, **С ба Г** 63:58. Сэрэмжлүүлэгдсэн хүн бүр хөршөө сэрэмжлүүлэх ёстой, **С ба Г** 88:81. Энэ мэргэн ухааны үгсийг өгснөөр би та нарыг сэрэмжлүүлсэн, мөн урьдчилан сэрэмжлүүлж байна, **С ба Г** 89:4.

ТАГТААНЫ ТЭМДЭГ. Ариун
Сүнснийг мөн үз

Иохан Баптист үүгээр Мессиаг танихын тулд урьдчилан зохион байгуулагдсан тэмдэг (**Иохан** 1:32–34). Ариун Сүнснийг гэрчлэхээр дэлхий бүтээгдэхээс өмнө тагтааны бэлэг тэмдэг бий болсон хэмээн Иосеф Смит заажээ; тийм учраас, чөтгөр тагтааны тэмдгээр ирж чадахгүй.

Бурханы Сүнс тагтаа адил бууж ирэв, **Мат.** 3:16. Есүсийг баптисм хүртээний дараа Ариун Сүнс тагтааны хэлбэрээр доош бууж ирэв, **1 Ниф.** 11:27. Тэнгэр нээгдэж, мөн Ариун Сүнс түүн дээр тагтаа хэлбэрээр доош бууж ирэхийг би Иохан, гэрчилж мөн харав, **С ба Г** 93:15.

ТАЙТГАРУУЛАГЧ. Ариун Сүнс;
Есүс Христийг мөн үз

Судруудад хоёр Тайтгаруулагчийн тухай өгүүлдэг. Эхнийх нь Ариун Сүнс (**Иохан** 14:26–27; **Моро.** 8:26; **С ба Г** 21:9; 42:17; 90:11). Хоёр дахь Тайтгаруулагч нь Их Эзэн Есүс Христ юм (**Иохан** 14:18, 21, 23). Хэн нэгэн Хоёрдахь Тайтгаруулагчийг олж авахад Есүс Христ түүнд үе үе үзэгдэж, Эцэгийг илчилж, мөн түүнд нүүр тулан заах болно (**С ба Г** 130:3).

ТАЛАНТ

Эртний хүндийн хэмжүүр түүнчлэн их үнэ бүхий мөнгөн дүнгийн хэмжүүр. Энэ нь тэрчлэн Есүс Христийн сайн мэдээ мэт зарим агуу үнэт зүйлсийн бэлэгдэл болдог (**Мат.** 25:14–29; **Ифер** 12:35; **С ба Г** 60:2, 13).

ТАЛАРХАЛ, ТАЛАРХАЛ
ИЛЭРХИЙЛЭХ,
ТАЛАРХАЛТАЙ. Адислагдсан,
Адислал, Адислах; Шүтэн
бишрэхийг мөн үз

Бурханаас хүлээн авсан адислалуудаа талархах. Талархлаа илэрхийлэх нь Бурханд тааламжтай бөгөөд түүнд талархах нь үнэн сүсэг биш-

рэл мөн. Бид Их Эзэнд бүх зүйлийн төлөө талархах ёстой.

Их Эзэнд талархал өргөх нь сайн зүйл юм, **Дуул.** 92:1. Талархалтайгаар түүний оршихуйн өмнө ир, **Дуул.** 95:1–2. Түүнд талархалтай байж мөн түүний нэрийг адисал, **Дуул.** 100:1–5. Талархал өргөхөө бүү зогсоо, **Ефес** 1:15–16. Талархалтай бай, **Кол.** 3:15. Бидний Бурханд адислалууд, мөн алдар суу, талархал хийгээд хүндэтгэл байг, **Илч.** 7:12. Ай та нар тэнгэрлэг Хаандаа талархах нь ямар их зохистой билээ, **Моз.** 2:19–21. Өдөр бүр талархалтайгаар амьдар, **Алма** 34:38. Өглөө босохдоо зүрх сэтгэл чинь Бурханд хандах талархлаар дүүрэн байг, **Алма** 37:37. Бүх зүйлийг залбирал ба талархалтайгаар хийх ёстой, **С ба Г** 46:7. Чи Бурханд талархал өргөх шаардлагатай, **С ба Г** 46:32. Эдгээр зүйлүүдийг та нар талархалтайгаар хий, **С ба Г** 59:15–21. Эдгээр адислалуудыг Их Эзэний гараас талархах зүрх сэтгэлтэйгээр хүлээн ав, **С ба Г** 62:7. Бүх зүйлүүдийг талархалтайгаар хүлээн авах тэрээр алдар суут болгогдох болно, **С ба Г** 78:19. Бүх зүйлд таларх, **С ба Г** 98:1 (1 Тес. 5:18). Их Эзэнийг магтаалын залбирал болон талархлаар магтагтун, **С ба Г** 136:28.

ТАЛБАЙ. Дэлхий; Их Эзэний жимсний цэцэрлэгийг *мөн үз*

Сударт тариаланд буюу бэлчээр болгон ашигладаг задгай газар. Энэ нь дэлхий болон түүний хүмүүсийн бэлэгдэл байх нь олонтаа тохиолддог.

Талбай бол дэлхий, **Мат.** 13:38. Тэнгэрийн хаанчлал бол талбайд нуусан эрдэнэстэй адил юм, **Мат.** 13:44. Уудам болоод цэлгэр тайлбайг би харав, **1 Ниф.** 8:9; 20. Талбай боловсорч гүйцсэн байв, **Алма** 26:5. Талбай цагаан аль хэдийн хадахад бэлэн байна, **С ба Г** 4:4 (С ба Г 6:3; 11:3; 12:3; 14:3; 31:4; 33:3; 7). Талбай нь дэлхий байлаа, **С ба Г** 86:1–2. Эдгээр хаант улсуудыг би талбай бүхий хүнтэй адилтгая, **С ба Г** 88:51.

ТАМ. Мөхөл; Мөхлийн хөвгүүд; Сүнсний үхэл; Чөтгөрийг *мөн үз*

Хожмын үеийн илчлэлт нь тамын тухай наад зах нь хоёр утгаар өгүүлсэн байдаг. Нэгдүгээрт, мөнх бус байдалд дуулгаваргүй байсан хүмүүсийн хувьд энэ нь түр хугацаагаар орших сүнсний ертөнц байдаг. Энэ утгаараа там нь төгсгөлтэй юм. Сүнснүүдэд тэнд сайн мэдээ заагдаж, мөн тэд нананчилсны дараа нэгэн цагт тэд өөрсдийн зохистой байдлын дагуу алдар суугийн аль нэг зэрэгт амилуулагдах болно. Наманчлаагүй хэдий ч мөхлийн хөвгүүд биш тэд, Мянган жилийн туршид тамд үлдэх болно. Мянган жилийн энэхүү тарчлалын дараа тэд телестиел алдар сууд амилуулагдах болно (С ба Г 76:81–86; 88:100–101).

Хоёрдугаарт, Христийн цагаатгалаар гэтэлгэгдээгүй тэдний хувьд энэ бол байнгын байх газар нь билээ. Энэ утгаараа, там нь “бузар хэвээр” байгаа тэдний хувьд байнгын юм. (С ба Г 88:35, 102). Энэ бол Эцэг Хүүг илчилсний дараа түүнийг үгүйсгэсээр байх Сатан, түүний элчүүд, түүнчлэн мөхлийн хөвгүүдийн мөнхөд орших газар юм (С ба Г 76:43–46).

Судрууд тамыг заримдаа гадаад харанхуй гэсэн байдаг.

Давидын бодгаль тамд үлдэхгүй, **Дуул.** 16:10 (Дуул. 86:13). Тамд, унтаршгүй галд ор, **Марк** 9:43 (Моз. 2:38). Баян хүн тамд тарчлан байхдаа хараагаа дээшлүүлэв, **Лук** 16:22–23 (С ба Г 104:18). Үхэл ба там нас барагсдыг гаргаж өгөв, **Илч.** 20:13. Байр, тийм ээ, бүр тэрхүү аймшигт там бэлтгэгдсэн, **1 Ниф.** 15:35. Маханбодийн хүсэл таашаал нь биднийг доош тамд аваачих хүчийг чөтгөрийн сүнсэнд өгдөг билээ, **2 Ниф.** 2:29. Үхэл болон тамаас чөлөөлөгдөх бидний замыг Христ бэлтгэсэн юм, **2 Ниф.** 9:10–12. Бузар булай хэвээрээ үлдэх тэд үүрдийн тарчлалд очдог, **2 Ниф.** 9:16. Чөтгөр тэдний бодгалийг хуурч, мөн тэднийг бол-

гоомжтойгоор там уруу хөтөлдөг, **2 Ниф.** 28:21. Есүс бодгалийг минь тамаас гэтэлгэсэн билээ, **2 Ниф.** 33:6. Өөрсдийгөө тамын тарчлалаас салга, **Иаков** 3:11. Чөтгөрөөр боолчлолд аваачигдаж, мөн түүний хүсэл зоригоор устгал уруу хөтлөгдөх нь тамын гинж бөлгөө, **Алма** 12:11. Ёс бусчууд өөрсдийн амилуулалтын цагийг хүртэл гадаад харанхуйд хаягдах болно, **Алма** 40:13–14. Бузар булай тэд Бурхантай хамт орших нь тамд байснаас илүү зовлонтой байх байсан, **Морм.** 9:4. Миний гараас өгөгддөг шийтгэл нь эцэс төгсгөлгүй шийтгэл билээ, **С ба Г** 19:10–12. Там бол чөтгөр хийгээд түүний элчүүдэд бэлтгэсэн байр юм, **С ба Г** 29:37–38. Бурханыг хүлээн зөвшөөрдөг тэд үхэл болон тамын гинжнээс чөлөөлөгддөг, **С ба Г** 138:23.

ТАМХИ. Мэргэн Ухааны Үгийг үз

ТАНГАРАГ. Гэрээ; Санваарын тангараг ба гэрээг *мөн үз*

Судруудад хэрэглэгдсэнээр бол, ихэвчлэн ариун гэрээ буюу амлалт. Гэвч, ёс бус хүмүүс, түүний дотор Сатан болон түүний элчүүд хилэнцэт зорилгуудыг хэрэгжүүлэхийн тулд бас тангараг өргөдөг. Хуучин Гэрээний үед, тангараг хүлээн зөвшөөрөгддөг байжээ; гэвч хүмүүс Бурханы, эсвээс түүний бүтээлүүдийн нэрээр тангараг өргөх ёсгүй хэмээн Есүс Христ сургажээ (**Мат.** 5:33–37).

Би чиний эцэг Абрахамд тангарагласнаа биелүүлнэ, **Эхл.** 26:3. Хэрэв эр хүн ЭЗЭНд андгайлан, өөрийгөө үүрэг хариуцлагад хүлэхээр тангарагласан бол тэр үүнийгээ зөрчих ёсгүй, **Тоол.** 30:2. Бурханы хуулинд алхахын тулд тэд тангарагт оров, **Нех.** 10:29. Эзэнд тангарагласнаа чи биелүүлэх ёстой, **Мат.** 5:33 (Номл. үгс 5:1–2; 3 Ниф. 12:33). Итгэлтнүүд аврагдах болно хэмээн Бурхан андгайлсан билээ, **Евр.** 6:13–18. Зорамыг бидэнд тангараглахад, бидний айдас замхрав, **1 Ниф.** 4:37. Аммоны хүмүүс

дахин хэзээ ч цус урсгахгүй хэмээн тангараглав, **Алма** 53:11. Ес бус нифайчууд Сатантай нууц тангаргууд хийгээд гэрээнүүд хийв, **Хил.** 6:21–30. Санваарын тангараг болон гэрээгээр дамжуулан хүмүүн мөнх амьдралыг олдго бөлгөө, **С ба Г** 84:33–42. Амлалтын Ариун сүнсээр лацдагдаагүй бүх гэрээ, хэлцэл, үүрэг, хариуцлага мөн тангаргууд нь хүмүүсийг нас нөгчихөд төгсгөл болдог, **С ба Г** 132:7.

ТАРААГДАЛТ. Израил—

Израилын тараагдалтыг үз

ТАТВАР ХУРААГЧ. Ромын эзэнт гүрнийг *мөн үз*

Эртний Ромд засгийн газрын төлөө татвар хураагч. Иудейчүүд татвар хураагчдыг үзэн ядах нь нийтлэг байлаа. Зарим татвар хураагчид сайн мэдээг сайшаан хүлээн авчээ (**Мат.** 9:9–10; **Лук** 19:2–8).

ТАХИЛЫН ШИРЭЭ.

Золиослолыг *мөн үз*

Золиослол, өргөлүүд болон бишрэн шүтэхэд ашиглагддаг байгууламж.

Ноа Их Эзэнд тахилын ширээ босгож шатаалт өргөл өргөжээ, **Эхл.** 8:20. Абрам Их Эзэнд тахилын ширээ босгов, **Эхл.** 12:7–8. Тахилын ширээн дээр Абрахам хүү Исаакаа хүлжээ, **Эхл.** 22:9 (Эхл 22:1–13). Иаков тэнд тахилын ширээ босгож мөн тэр газрыг Ел-бет-ел хэмээн нэрлэв, **Эхл.** 35:6–7. Елиа тахилын ширээ босгож, Баалын санваартнуудыг сорив, **Хаад.** дээд 18:17–40. Хэрэв чи тахилын ширээн дээр өргөлөө авчирсан бол эхлээд ахтайгаа эвлэр, **Мат.** 5:23–24. Бурханы үгний учир алагдсан хүмүүсийн сэтгэлүүдийг тахилын ширээн доор байхыг би харав, **Илч.** 6:9 (С ба Г 135:7). Лихай чулуун тахилын ширээ босгож, Их Эзэнд талархав, **1 Ниф.** 2:7. Элкенагийн тахилын ширээн дээр Абрахам үхлээс аврагджээ, **Абр.** 1:8–20.

ТАЧААДАЛТ, ТАЧААНГУЙ.

Ариун явдал; Бэлгийн харилцааны ёс суртахуунгүй явдал; Завхайрал; Садар самуун; Тачаадахыг *мөн үз*

Бие махбодийн шударга бус дур тачаал, ялангуяа бэлгийн харилцааны ёс суртахуунгүй хүсэл буюу дур тачаал.

Түүний эзний эхнэр Иосефыг харцаараа өдөв, **Эхл.** 39:7. Эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр завхайрсан хэрэг, **Мат.** 5:28 (3 Ниф. 12:28). Сэтгэлийн чинь эсрэг дайн хийдэг махан биеийн хүслийг цээрлэ, **1 Петр** 2:11. Махан биеийн хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал нь Эцэгээс бус болой, **1 Иохан** 2:16. Нүдээрээ шунасныхаа араас бүү яв, **Алма** 39:9. Ариун хуулиудыг зөрчсөнөөр хүн хүсэл тачаангуй болдог, **С ба Г** 20:20. Хэрэв хэн нэгэн зүрхэндээ садар самууныг үйлдвээс түүнд Сүнс байх нь үгүй, **С ба Г** 63:16. Өөрсдийн бүх шуналт хүслүүдээ боль, **С ба Г** 88:121. Хүмүүн зуурдын, тачаангуй, чөтгөрийн адил болж эхлэв, **Моисе** 5:13 (Моз. 16:3; Моисе 6:49).

ТЕАНКУМ

Мормоны Номонд нифайчуудын цэргийн их жанжин (Алма 50:35; 51–52; 61–62).

ТЕЙЛОР, ЖОН

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гурав дахь Ерөнхийлөгч.

Арванхоёрын Зөвлөхөөр дуудагдав, **С ба Г** 118:6 (С ба Г 124:128–29). Иосеф Смит Хайрум Смит хоёр алагдсан тухай бичжээ, **С ба Г** 135. Аллагын үеэр шархдав, **С ба Г** 135:2. Сүнсний дэлхийд олны дунд байхыг нь Иосеф Ф.Смит харжээ, **С ба Г** 138:53–56.

ТЕЛЕСТИЕЛ АЛДАР СУУ. Алдар суугийн зэрэглэлүүдийг *мөн үз*

Эцсийн шүүлтийн дараа хүмүүсийн оршин амьдрах алдар суугийн гурван зэрэглэлийн хамгийн доод нь.

Паул однуудын алдар сууг харжээ, **1 Кор.** 15:40–41. Иосеф Смит Сидней Ригдон хоёр телестиел алдар сууг харсан ажээ, **С ба Г** 76:81–90. Телестиел дэлхийн оршин суугчдын тоо нь од адил тоолшгүй, **С ба Г** 76:109–12. Телестиел хаант улсын хуулийг тэвчиж чадаагүй тэд телестиел алдар суунд оршиж чадахгүй, **С ба Г** 88:24, 31, 38.

ТЕРРЕСТРИЕЛ АЛДАР СУУ.

Алдар суугийн зэрэглэлүүдийг *мөн үз*

Эцсийн шүүлтийн дараа хүмүүсийн амьдрах алдар суугийн гурван зэрэглэлийн хоёр дахь нь.

Паул террестриел алдар суу сарны алдар суутай адил болохыг харжээ, **1 Кор.** 15:40–41. Иосеф Смит Сидней Ригдон хоёр террестриел алдар сууг харжээ, **С ба Г** 76:71–80. Террестриел алдар суу нь телестиелийнхээс ялгаатай, **С ба Г** 76:91. Террестриел хаант улсын хуулийг тэсвэрлэж чадаагүй тэд террестриел алдар суунд оршиж чадахгүй, **С ба Г** 88:23, 30, 38.

ТЕСАЛОНИКЧУУД, ТЭДЭНД

БИЧСЭН ЗАХИДЛУУД. Паул; Паулын захидлуудыг *мөн үз*

Шинэ Гэрээний хоёр ном. Тэдгээр нь анхандаа мэ 50-иад онд Европт анх удаа айлчлах үеэр Коринтад байхдаа тесалоникчуудад бичсэн Паулын захидал байжээ. Тесалоникт түүний хийсэн ажлыг Үйлс 17-д дүрсэлсэн байдаг. Паул Тесалоникт ирэхийг хүссэн боловч чадаагүй билээ (1 Тес. 2:18). Тийм учраас тэрээр хөрвөгчдийн сэтгэл санааг өргөж, тэд хэрхэн ажиллаж байгаа талаар сураг дуулахаар тэрээр Тимотыг тийш нь явуулжээ. Паул эхний захидлаа Тимотыг эргэж ирсэнд баярлаж талархсандаа бичсэн байдаг.

Нэгдүгээр Тесалоник: Бүлэг 1–2 нь Паулын мэндчилгээ хийгээд Гэгээнтнүүдийн төлөөх түүний залбирлыг багтаадаг; бүлэг 3–5 нь сүнсний

өсөлт, хайр, ариун явдал, хичээл зүтгэл хийгээд Есүс Христийн хоёрдахь ирэлтийн тухай зааврыг агуулдаг.

Хоёрдугаар Тесалоник: Бүлэг 1 нь Гэгээнтнүүдийн залбирлыг агуулдаг. Бүлэг 2 нь урвалт тохиох тухай өгүүлдэг. Бүлэг 3 нь сайн мэдээний зарчмын ялгуусан ялалтын төлөөх Паулын залбирлыг агуулдаг.

ТИМОТ. Паулыг мөн үз

Шинэ Гэрээнд, Паулын тохинууллын үе дэх түүний номлолын залуу хамтрагч (Үйлс 16:1–3; 2 Тим. 1:1–5); грек эцэг, иудей эхийн хүү, тэрээр эцэг эхийн хамт Листрад амьдардаг байжээ.

Тимотын тухай Паул итгэлт хүүгийнхээ адилаар ярьдаг байв (1 Тим. 1:2, 18; 2 Тим. 1:2). Тимот нь Паулын хамгийн итгэл хүлээлгэсэн хийгээд найдвартай туслагч байсан болов уу (Филип 2:19–23).

ТИМОТ, ТҮҮНД БИЧСЭН

ЗАХИДЛУУД. Паул, Паулын захидлууд; Тимотыг мөн үз

Шинэ Гэрээний хоёр ном. Аль аль нь анхандаа Паулаас Тимотод бичсэн захидлууд байв.

1 Тимот: Паул анхны захидлаа тэрээр анхны удаад шоронгоос суллагдаад бичжээ. Тэрээр Тимотыг Ефест үлдээсэн бөгөөд дараа нь буцаж ирнэ хэмээн бодож байжээ (1 Тим. 3:14). Хэдий тийм ч, Паул өөрийгөө саатна гэж бодоод түүнд үүргээ гүйцэтгэхэд нь зөвлөгөө өгч урамшуулахын тулд Македониас Тимотод бичжээ (1 Тим. 1:3).

Бүлэг 1 нь Паулын мэндчилгээ хийгээд тэрчлэн Сүмд замаа олох тухай тэдний мунхаг бодлуудын талаарх түүний зааврыг агуулдаг. Бүлэг 2–3 нь олон нийтийн шүтлэг бишрэл хийгээд тохинуулагчдын зан төлөв болон биеэ авч явах байдлын талаар удирдамж чиглэл өгдөг. Бүлэг 4–5 нь хожмын үеийн урвалт хийгээд удирдаж буй хүмүүсээ

хэрхэн тохинуулах тухай Тимотод өгсөн зөвлөгөөг агуулдаг. Бүлэг 6 нь итгэлтэйгээ нотолж мөн дэлхийн баялгаас зайлсхийх ухуулга.

2 Тимот: Хоёр дахь захидлаа Паул алагдахаасаа дөнгөж өмнөхөн хоёр дахь удаа шоронд хоригдож байхдаа бичжээ. Энэ нь Төлөөлөгчийн сүүлчийн үгсийг агуулдаг бөгөөд агуу зориг хийгээд итгэлээр үхэлтэй тулгарч байгааг харуулдаг.

Бүлэг 1 нь Паулын мэндчилгээ хийгээд Тимотод өгсөн үүргийг агуулдаг. Бүлэг 2–3-т өмнө нь тулгарах аюулын сорилтны талаар хэд хэдэн сануулга зааврууд байдаг. Бүлэг 4 нь урвалтыг хэрхэн даван гарах тухай найз нартаа өгсөн зөвлөгөөг агуулсан Паулын захиас юм.

ТИТ. Паул; Паулын захидлууд;

Титэд бичсэн захидлыг мөн үз

Шинэ Гэрээнд, Иерусалим уруу Паултай хамт явж, хожим нь номлогч болсон итгэлтэй грек хөрвөгч (Гал. 2:1–4; 2 Тим. 4:10). Коринт дахь Гэгээнтнүүдэд Паулын бичсэн анхны захидлыг Тит хүргэж өгчээ (2 Кор. 7:5–8, 13–15).

ТИТ, ТҮҮНД БИЧСЭН

ЗАХИДАЛ. Паул; Паулын захидлууд; Титийг мөн үз

Паул Ромын шоронд түр хугацаанд хоригдоогүй байхдаа тэрээр Кретэд байсан Титэд захидал бичжээ. Захидлын гол санаа нь дотоод сахилга бат болон Сүмийн зохион байгуулалттай холбоотой асуултуудад зориулагдсан байв.

Бүлэг 1 нь Паулын мэндчилгээ, түүнчлэн заавар хийгээд бишопуудад хандсан ерөнхий асуудлуудыг агуулдаг. Бүлэг 2–3 нь ерөнхий сургаал хийгээд Кретийн Сүмийн янз бүрийн бүлгүүдийн байдлын талаарх түүний хувийн захиасыг агуулдаг. Төөрөгдлийг ялан гарч, хүчтэй, итгэлтэй байх болон сайн үйлүүдийг хийхэд нь Гэгээнтнүүдийг Паул дэмжиж байв.

ТИТЭМ. Мөнх амьдралыг *мөн үз*

Жолоодогчдын тэргүүн дээр өмсгөдөг дугуй хэлбэртэй хээ бүхий чимэглэл. Энэ нь селестиел хүч, эзэгнэл болон бурханлиг чанарын бэлэгдэл байж болдог. Бурханы бүх зарлигуудыг эцсээ хүртэл сахидаг тэд мөнх амьдралын титмийг хүлээн авах болно (С ба Г 20:14 Мосе 7:56 ИС—М 1:1-ийг үз.)

Зөвт байдлын титэм нь надад зориулагдсан, **2 Тим.** 4:8. Та нар алдрын гандашгүй титмийг хүлээн авна, **1 Петр** 5:4. Их Эзэнд нас барсан үхэгсэд зөв шударгын титмийг хүлээн авах болно, **С ба Г** 29:13. Тэд миний Эцэгийн харшуудад титэм хүлээн авах болно, **С ба Г** 59:2. Өөрсдөд нь бэлтгэгдсэн титэмд хүрч болохын тулд Их Эзэн Гэгээнтнүүдийг бэлтгэдэг, **С ба Г** 78:15. Их Эзэн өөрийн баруун гар талд сүр жавхлангийн титмийг Гэгээнтнүүддээ амласан билээ, **С ба Г** 104:7.

ТОМАС

Шинэ Гэрээнд, мөнх бус тохинуулынхаа үед Аврагчийн сонгосон анхны Арванхоёр Төлөөлөгчийн нэг. Грек нэр нь Дидамус (Мат. 10:2–3; Иохан 14:5; 20:24–29; 21:2). Хэдийгээр Томас Аврагчийг өөрийн биеэр харах хүртэл Есүсийн амилалтад эргэлзэж байсан ч, хүчтэй зан төлөв нь хавчлагатай нүүр тулах хийгээд Их Эзэнтэйгээ хамт үхэхэд нь түүнийг бэлэн болгожээ (Иохан 11:16; 20:19–25).

ТОМИЛОЛТ, ТОМИЛОХ. Албан

тушаал, Албан тушаалтан;
Бурханаас дуудагдах; Гар тавилт; Дуудлага; Дуудах;
Санваар; Эрх мэдлийг *мөн үз*

Эрх мэдэл буюу албан тушаалд томилох буюу олгох. Их Эзэний Сүмд эрх мэдлийг ашиглахын тулд хүн, эрх мэдэл бүхий хүмүүсийн гар тавилтаар, түүнчлэн бошиглолоор Бурханаас дуудагдах ёстой (ИТ 1:5). Хэдийгээр хүн эрх мэдлийг томилолтоор хүлээн авдаг ч гэсэн, тэрээр

уг эрх мэдлийн онцгой түлхүүрүүдийг атгадаг хүмүүсийн удирдлага дор үүнийг ашигладаг.

Би чамайг үндэстнүүдэд эш үзүүлэгч болгон томилсон, **Иер.** 1:5. Та нар намайг сонгоогүй, харин би та нарыг сонгож мөн томилсон, **Иохан** 15:16. Бурханаас эрх мэдэл хүлээн авсан тул Алма санваартнуудыг томилов, **Моз.** 18:18. Хүмүүс ариун ёслолоор дээд санваарт томилогддог бөлгөө, **Алма** 13:1–9. Есүс арванхоёр шавийг дуудаж мөн томилов, **3 Ниф.** 12:1. Ахлагчид нь санваартнууд хийгээд багш нарыг гар тавилтаар томилдог, **Моро.** 3:1–4. Та нар бага эзрэг хүлээ, учир нь та нар хараахан томилогдоогүй байна, **С ба Г** 5:17. Иосеф Смит Есүс Христийн Төлөөлөгчөөр томилогдов, **С ба Г** 20:2 (С ба Г 27:12). Сүмийн саналгүйгээр нэг ч хүн томилогдох ёсгүй, **С ба Г** 20:65. Тэрээр эрх мэдэл бүхий хэн нэгнээр томилогдохоос бусдаар миний сайн мэдээг номлох нь хэн нэгэнд өгөгдөх ёсгүй, **С ба Г** 42:11. Ахлагчид миний сайн мэдээг номлохоор томилогддог болой, **С ба Г** 50:13–18. Сүмийн бусад бүх албан тушаалтнуудыг томилж, мөн тогтсон жаягт оруулах нь Арванхоёрын үүрэг юм, **С ба Г** 107:58. Бибээр эцгүүдийн адислалууд хийгээд би үүгээр томилогдох ёстой тэрхүү эрхийн төлөө эрэлхийлж байв, **Абр.** 1:2. Иосеф Смит Оливер Каудери хоёр бие биенээ Аароны санваарт томилов, **ИС—Т** 1:68–72.

ТООЛЛОГО. Пентатеухыг *мөн үз*

Хуучин Гэрээний дөрөв дэх ном. Тооллогын номыг Мосе бичжээ. Тооллогын ном нь Синайн уулнаас Канааны хил дээр орших Моабын тал уруу хийсэн израилчуудын аяллын түүхтэй холбоотой. Амжилттай байхаа үргэлжлүүлэхийн тулд Бурханы хүмүүс итгэлтэйгээр алхаж, түүний амлалтуудад итгэх ёстой гэсэн чухал зүйлийг заадаг. Энэ нь дуулгаваргүй байдлынх нь улмаас израилчуудад өгсөн Бурханы шийт-

гэлийн талаар өгүүлж мөн Израилын хуулиудын талаарх мэдээллээр хангадаг. Номны нэр нь нийтийн мэдэх хүн амын тооллогоос үүдэлтэй юм (Тоол. 1–2, 26).

Бүлэг 1–10 нь Синайгаас явахаар израилчууд бэлтгэсэн тухай өгүүлдэг. Бүлэг 11–14 нь аяныг, Канаан уруу тандуулууд илгээсэн тухай, түүнчлэн амлагдсан нутагт орохоос Израил татгалзсаныг дүрслэн харуулдаг. Бүлэг 15–19 нь янз бүрийн хуулиуд хийгээд түүхэн үйл явдлуудыг цэдэглэсэн байдаг. Бүлэг 20–36 нь сүүлчийн нэг жил аглаг буйдад байсан хүмүүсийн түүх юм.

ТОС. Өвчтөнийг адислах нь; Тос түрхэх; Чидуны модыг *мөн үз*

Судруудад тос гэж дурдагдахад энэ нь ихэвчлэн чидуны тос байдаг. Хуучин Гэрээний үеэс чидуний тосыг ариун сүм болон табернеклын ёслолуудад, тосолгоонд, чийдэн асаахад, түүнчлэн хүнсэнд хэрэглээр иржээ. Чидуны тос нь заримдаа цэвэр ариуны хийгээд Ариун Сүнсний тэрчлэн түүний нөлөөний бэлгэдэл болдог (1 Сам. 10:1, 6; 16:13; Иса. 61:1–3).

Тахилч тосыг баруун чихний гэдсэн дээр түрхэнэ, **Лев.** 14:28–29. Чамайг Өөрийн ард түмний хаан болгон, тослуулахаар ЭЗЭН намайг илгээв, **1 Сам.** 15:1. Бэлэвсэн эхнэрийн тосны сав хоосорсонгүй, **Хаад.** дээд 17:10–16. ЭЗЭН миний толгойг тосоор тослов, **Дуул.** 23:5. Тэд өвчтэй олон хүнийг тосоор тосолжээ, **Марк** 6:13. Ахлагчид түүнийг тослон, түүний төлөө залбираг, **Иаков** 5:13–15. Дэнлүүгээ бэлтгэж асаан мөн тосоо авч явагтун, **С ба Г** 33:17 (Мат. 25:1–13).

ТОСЛОГДСОН НЭГЭН. Есүс Христ; Мессиаг *мөн үз*

Есүсийг Христ (грек үг) болон Мессиа (арамей үг) гэж дууддаг. Хоёр үг нь хоёулаа “тослогдсон нэгэн” гэсэн утгатай. Тэрээр хүн төрөлхт-

ний авралтай холбоотой бүх зүйлд Эцэгийн хувийн төлөөлөгч байхаар Эцэгээр *тослогдсон* нэгэн билээ.

Их Эзэн надад тос түрхсэн билээ, **Иса.** 61:1–3. Тэрээр сайн мэдээг номлохоор тос түрхэгдсэн нэгэн, **Лук** 4:16–22. Есүс Бурхан Эцэгээр тос түрхэгдсэн, **Үйлс** 4:27. Бурхан Назарын Есүст тос түрхсэн, **Үйлс** 10:38.

ТОСЛОХ, ТОС ТҮРХЭХ.

Өвчтөнийг адислах; Тосыг *мөн үз*

Эрт дээр үед Аарон буюу санваартнууд, эсвээс Израилын дээр захирах хад гэхчлэн онцгой үүрэг гүйцэтгэх хүмүүсийг Их Эзэний бошиглогчид тосолдог байв. Сүмд өнөөдөр тос түрхэх гэдэг нь нэг буюу хоёр дусал ариулсан тосыг хүний толгой дээр онцгой адислалын хэсэг болгон түрхдэг. Энэ нь зөвхөн Мелкизедек санваартны эрх мэдэл болон хүчээр хийгдэнэ. Тос түрхсэний дараа, мөн энэхүү санваарын эрх мэдлээр үйлдэгч хүн тослолтыг батлан мөн тослогдсон хүнд тусгай адислал өгч болно.

Тэд надад тохинуулж болохын тулд тэдэнд тос түрхэн, тэднийг ариул, **Ег.** 28:41 (Лев. 8:6–12, 30). Израилын миний хүмүүсийн ахмад болгохоор түүнд тос түрх, **1 Сам** 9:16; 10:1. Ахлагч нар өвчтөнд тос түрхэж адислах ёстой, **Иаков** 5:14–15 (С ба Г 42:44).

ТОХИНУУЛАГЧ ТЭНГЭР

ЭЛЧҮҮД. Тэнгэр элчүүдийг үз

ТОХИНУУЛАХ. Санваар;

Үйлчлэлийг *мөн үз*

Дэлхий дээр Их Эзэний ажлыг хийх. Бурханы сонгосон үйлчлэгчид түүний ажилд тохинуулахын тулд Бурханаас дуудагдах ёстой. Жинхэнэ тохинуулагчид Их Эзэний хүсэл зоригийг хэрэгжүүлэхдээ, өөрсдийн албан тушаалын үүргүүдэд Их Эзэнийг төлөөлж, түүний төлөөний хүмүүс болж, ийнхүү хүн төрөлхтний авралын тул зайлшгүй

шаардлагатай ажлыг гүйцэтгэн ажилладаг (С ба Г 64:29). Гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэхийн тулд, тохинууллын ажлын тул Төлөөлөгчид, бошиглогчид, евангелистууд, дээд санваартнууд, далууд, ахлагчид, бишопууд, санваартнууд, багш нар, диконууд, тусламжууд, түүнчлэн засгийн газруудыг Их Эзэн өгсөн байдаг (Ефес 4:11–16; Шаст. дээд 12:12–28; С ба Г 20; 107).

Их Эзэний нэрээр тохинуулахын тулд түүнийг Их Эзэн сонгожээ, **Дэд хууль**. 18:5. Хүмүүс та нарыг бидний Бурханы үйлчлэгчид гэж нэрлэх болно, **Иса**. 61:6. Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд ирсэн, **Мат**. 20:26–28. Чамайг гэрч, үйлчлэгч болгохоор би чамд үзэгдсэн юм, **Үйлс** 26:16–18. Бурхан бол та нарын ариун хүмүүст үйлчилсэн та нарын үйл хэргийн хайрыг мартахаар шударга бус биш, **Евр**. 6:10. Үйлчилдэг хүн нь Бурханаас тэтгэгддэг хүчээр үйлдэг, **1 Петр** 4:10–11. Тэд нэг нэгэндээ зааж мөн тохинуулсан болой, **3 Ниф**. 26:19. Евангелийн тохинуудагчдыг томилох нь Арванхоёрын үүрэг мөн, **С ба Г** 107: 39–40. Дээд санваартан нь цаг зуурын зүйлүүдийн тохинуулалд онцгойлон адислагдаж болно, **С ба Г** 107:71–72. Эдгээр далтангууд нь аялагч тохинуулагчид юм, **С ба Г** 107:93–97. Ахлагчид нь миний сүмд үйл ажиллагаа явуулж байгаа тохинуулагчид болон томилогддог байх ёстой, **С ба Г** 124:137.

ТӨГС

Бүрэн, дүүрэн, түүнчлэн бүрэн хөгжсөн; төгс зөв шударга. Төгс нь түүнчлэн нүгэл буюу хилэнцгүй гэсэн утгатай. Христийн үнэн дагалдагчид түүний нигүүлсэл хийгээд цагаатгалаар дамжин төгс болж болно.

Зүрх сэтгэл чинь Эзэнд төгс байг, **Хаад**. дээд 8:61. Эцэг тань төгс байдаг шиг та нар мөн төгс бай, **Мат**. 5:48 (3 Ниф. 12:48). Хэрэв хүн үгээр

гомдоодоггүй бол, тэр нь төгс хүн байдаг, **Иаков** 3:2. Итгэл бол юмсын тухай төгс мэдлэгтэй байх нь бус юм, **Алма** 32:21, 26. Бурхан төгс Бурхан байхын тулд Цагаатгал хийгдсэн билээ, **Алма** 42:15. Моронай бол төгс ойлголт бүхий хүн байв, **Алма** 48:11–13, 17–18. Ямар нэг зүйл нь Бурханаас уу эсвэл чөтгөрөөс үү гэдгийг шүүж мөн мэдэхэд нь Христийн Сүнс хүн болгонд өгөгддөг билээ, **Моро**. 7:15–17. Христэд ирж мөн түүнд төгөлдөржигтүн, **Моро**. 10:32. Та нар төгөлдөржих хүртэл тэвчээрт үргэлжлүүл, **С ба Г** 67:13. Эд бол Есүсээр дамжин төгс болгогдсон шударга хүмүүс, **С ба Г** 76:69. Сүм дэх албан тушаалууд нь Гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэхийн тулд юм, **С ба Г** 124:143 (Еф. 4:11–13). Амьд байгаа хүмүүс өөрсдийн нас барагсадгүйгээр төгс бус юм, **С ба Г** 128:15, 18. Ноа бол шударга, өөрийн үеийнхэн дотор төгс хүн байв, **Моисе** 8:27.

ТӨГСГӨЛГҮЙ. Бурхан, Бурхан
Тэргүүтнийг мөн үз

Түүний мөнхийн шинж чанарыг харуулсан Бурханы нэг нэр (С ба Г 19:10–12; Моисе 1:3; 7:35).

ТӨЛӨӨЛӨГЧ. Илчлэлт;
Шавийг мөн үз

Грек хэлэнд Төлөөлөгч нь “урагш илгээгдсэн нэгэн” гэсэн утгатай. Газар дэлхий дээрх өөрийнхөө тохинуулахын үед хамгийн ойрынхоо дагалдагч мөн туслагч байлгахаар сонгож мөн томилсон Арванхоёрт Есүсийн өгсөн нэр (Лук 6:13; Иохан 15:16). Тэрээр тэнгэрт дээшлэн одсоныхоо дараа өөрийгөө төлөөлүүлэхээр мөн өөрийнх нь өмнөөс тохинуулахаар гэднийг урагш илгээжээ. Эртний болон өнөөдрийн сэргэсэн Сүмд хийгээд Арванхоёрын Чуулга аль алинд нь Төлөөлөгч бол бүх дэлхийд Есүс Христийн тусгай гэрч байж, түүний тэнгэрлэг байдал болон нас барагсдаас тэрээр амилсныг гэрчилдэг (Үйлс 1:22 С ба Г 107:23).

Христийн сүм Төлөөлөгч болон бошиглогчдын суурин дээр баригддаг, **Ефес** 2:20; 4:11. Арванхоёр Төлөөлөгч Есүсийг дагаж явааг Лихай Нифай хоёр харав, **1 Ниф** 1:10; 11:34. Төлөөлөгчид Израилын угсааг шүүх болно, **Морм.** 3:18. Бошиглогчид болон Төлөөлөгчдийн үгсэд анхаарал үл тавих хүмүүс тусгаарлагдах болно, **С ба Г** 1:14 (3 **Ниф.** 12:1). Арванхоёрын дуудлага болон үүрэг илчлэгдэв, **С ба Г** 18:26–36. Иосеф Смит Төлөөлөгчөөр томилогдов, **С ба Г** 20:2; 21:1. Төлөөлөгчид нь Христийн нэрийн тусгай гэрчүүд бөгөөд тохинуулын түлхүүрүүдийг атгадаг, **С ба Г** 27:12 (**С ба Г** 112:30–32). Арванхоёрын чуулга Тэргүүн Зөвлөлтэй эн тэнцүү эрх мэдлийг үүсгэдэг, **С ба Г** 107:23–24. Арванхоёр нь Тэргүүлэгч аялагч дээд зөвлөл болой, **С ба Г** 107:33. Төлөөлөгчид нь номлолын ажлын түлхүүрүүдийг атгадаг, **С ба Г** 107:35. Төлөөлөгчдийн зарим үүргүүд тайлбарлагддаг, **С ба Г** 107:58. Би бүх Арванхоёрт хэлнэ: намайг дага, мөн миний хонинуудыг тэжээ, **С ба Г** 112:14–15. Бид Төлөөлөгчдөд итгэдэг, **ИТ** 1:6.

Төлөөлөгчдийн сонголт: Төлөөлөгчид Их Эзэнээр сонгогдсон юм (**Иохан** 6:70; 15:16).

Шавь нараасаа Есүс арванхоёр Төлөөлөгчийг сонгов, **Лук** 6:13–16. Маттаиа Төлөөлөгч байхаар сонгодов, **Үйлс** 1:21–26. Оливер Каудери, Давид Витмер Арванхоёрыг эрж олохоор зарлигдуулав, **С ба Г** 18:37–39.

ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ҮЙЛС.

Лукийг мөн үз

Энэ ном нь Теофилд Лукийн бичсэн хоёр хэсэг ажлын хоёр дахь хэсэг нь юм. Эхний хэсгийг нь Лукийн Сайн мэдээ гэдэг. Бүлэг 1–12 нь Аврагчийн нас баралт мөн амилалтын дөнгөж дараахан Петрийн удирдлаган дор Арванхоёр Төлөөлөгчийн номлогчийн зарим чухал үйл ажиллагааг цэдэглэсэн болно. Бүлэг 13–28 нь Төлөөлөгч Паулын зарим аялал болон номлолын ажлыг харуулжээ.

ТӨЛӨӨЛӨН ХИЙХ. Ёслолууд—

Төлөөлөн хийх ёслол; Нас барагсдын авралыг үз

ТӨРӨЛТӨД ХЯНАЛТ ТАВИХ. Гэр

бүл; Гэрлэлт, Гэрлэхийг мөн үз

Гэр бүлийн хос төрүүлэх хүүхдүүдийн тоог хязгаарлах буюу төрөлтөөс урьдчилан сэргийлэх замаар хяналт тавих.

Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэ, **Эхл.** 1:28 (**Моце** 2:28). Хүүхдүүд бол Их Эзэнээс ирдэг бэлэг, **Дуул.** 127:3–5. Лихайн гэр бүл Их Эзэний тул үр удмаа өсгөцгөөх ёстой байв, **1 Ниф.** 7:1. Гэрлэлт нь Бурханаас хүмүүнд томилогддог, **С ба Г** 49:15–17. Өргөмжлөгдсөн нэгэн нь үр удмын бүрэн бүтэн байдал хийгээд үргэлжлэлийг үүрд мөнхөд хүлээн авах болно, **С ба Г** 132:19, 63.

ТӨРСӨН. Бурханаас төрөх;

Бурханы хөвгүүд охид; Дахин төрсөн; Төрсөн Ганц; Христийн хүүхдүүдийг мөн үз

Төрөх. Хүүхэд төрүүлэх, удмаа үргэлжлүүлэх буюу оршин амьдрахад дуудах. Судруудад эдгээр үгнүүд нь ихэнхдээ Бурханаас төрөх гэсэн утгаар хэрэглэгддэг. Хэдийгээр Есүс Христ мөнх бус амьдралд Эцэгийн төрсөн ганц нь боловч бүх хүмүүс Христийг хүлээн зөвшөөрч, түүний зарлигуудыг дагаж мөн Ариун Сүнсний хүчээр шинэ хүн болсноор түүний сүнсний төрсөн хүүхдүүд болдог.

Өнөөдөр би чамайг төрүүлсэн, **Дуул.** 2:7 (**Үйлс** 13:33; **Евр** 1:5–6; 5:5). Түүний алдар суу нь Эцэгийн төрсөн ганцынх байв, **Иохан** 1:14 (2 **Ниф.** 25:12; **Алма** 12:33–34; **С ба Г** 76:23). Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн юм, **Иохан** 3:16 (**С ба Г** 20:21). Христ өөрийнхөө хүмүүсийг оюун санаагаар төрүүлсэн билээ, **Моз.** 5:7. Их Эзэнээр дамжин төрөгсөд бол Ууган Хүүгийн Сүм болой, **С ба Г** 93:22.

ТӨРСӨН ГАНЦ. Төрсөн; Есүс
Христийг *мөн үз*

Есүс Христийн өөр нэг нэр. Тэр бол Эцэгийн Төрсөн Ганц Хүү (Лук 1:26–35; Иохан 1:14; 3:16; 1 Ниф. 11:18–20; 2 Ниф. 25:12; Алма 7:10; 12:33; Мосе 7:62).

ТУГ

Судруудад зорилго буюу үзэл санаанд хүмүүс нэгдэн цугларч хүрээлдэг туг буюу далбаа. Эрт дээр үед туг нь тулалдаанд цугларах газрыг цэргүүдэд харуулах байв. Мормоны Ном болон Есүс Христийн Сүм нь дэлхийн бүх үндэстнүүдэд бэлэгдлийн туг мөн.

Тэр үндэстнүүд уруу туг өргөх болно, **Иса.** 5:26 (2 Ниф. 15:26). Иессийн үндэс туг мэт болно, **Иса.** 11:10 (2 Ниф. 21:10; С ба Г 113:6). Энх амгалангийн тугийг өргөгтүн, **С ба Г** 105:39.

ТУНГААН БОДОХ. Залбирал;
Илчлэлтийг үз

Судруудын талаар, эсвээс Бурханы зүйлүүдийн талаар бясалгах буюу гүнзгийгээр тунгаан бодох. Бурханы зүйлүүдийн талаар тунгаан бодох нь залбиралтай нэгдэхээрээ илчлэлт хийгээд ойлголтод хүрч болно.

Эдгээр зүйлүүдийг Мариа зүрхэндээ тунгаан бодов, **Лук** 2:19. Би зүрх сэтгэлдээ тунгаан суух зуур би алсад одов, **1 Ниф.** 11:1. Зүрх минь судруудыг тунгаадаг, **2 Ниф.** 4:15. Их Эзэний үзүүлсэн зүйлүүдийн талаар Нифай тунгаан бодсоор гэрийн зүг замаараа явав, **Хил.** 10:2–3. Та нар гэр гэртээ явцаа, мөн миний хэлсэн зүйлүүдийг эргэцүүлэн бодоцгоо, **3 Ниф.** 17:3. Их Эзэн ямар нигүүлсэнгүй байсаар буйг санаж мөн үүнийг зүрх сэтгэлдээ тунгаан бодогтун, **Моро.** 10:3. Өөрсдийнхөө хүлээн авсан зүйлүүдийн талаар тунгаан бодогтун, **С ба Г** 30:3. Бид эдгээр зүйлүүдийг бясалгаж байх үед, Их Эзэн бидний ойлголтын

мэлмийд хүрэв, **С ба Г** 76:19. Судруудын талаар тунгаан бодсоор би өрөөндөө сууж байв, **С ба Г** 138:1–11. Би үүнийг дахин дахин эргэцүүлэн бодсоор байлаа, **ИС—Т** 1:12.

ТУНХАГ. Вудрафф, Вилфорд;
Гэрлэлт; Гэрлэх—Олон эхнэр
авах ёсыг *мөн үз*

Сүм болон түүний гишүүд улс орны хуулинд захирагдаж олон эхнэр авах ёсонд дахин орохгүй хэмээн 1890 онд Ерөнхийлөгч Вилфорд Вудраффын тов тодорхой нотолсон албан тунхаг (С ба Г АТ—1). Бурханаас ирсэн үзэгдэл хийгээд илчлэлтийг баримтлан Ерөнхийлөгч Вудрафф энэхүү Тунхгийг гаргажээ.

ТҮМНИЙ ИХ ЭЗЭН. Есүс
Христийг *мөн үз*

Есүс Христийн өөр нэг нэр. Тэрээр тэнгэр ба дэлхийн түмнийг хаанчилж, мөн зөв шударгыг үйлдэгчдийг хилэнцийн эсрэг удирддаг (С ба Г 29:9; 121:23).

Түмний ЭЗЭН бол алдар суугийн Хаан мөн, **Дуул.** 24:10. Израилын Бурхан бол Түмний Их Эзэн мөн, **1 Ниф.** 20:2. Миний Сүнс хүмүүний төлөө ямагт зүтгэх нь үгүй хэмээн Түмний Их Эзэн хэлдэг, **С ба Г** 1:33.

ТЭВЧИХ. Бэрхшээл зовлон;
Тэвчээр; Уруу татах, Уруу
таталтыг *мөн үз*

Уруу таталт, эсэргүүцэл, бэрхшээл зовлонг үл хайхран Бурханы зарлигуудад үнэнч шударга байхад шийдвэр төгс, гуйвшгүй бат байх.

Эцсээ хүртэл тэвчсэн нь аврагдах болно, **Марк.** 10:22 (Марк 13:13). Өөрсдөд нь бат үндэс байхгүй тэд түр зуур тэсдэг, **Марк** 4:17. Энэрэл бүх зүйлийг тэсвэрлэдэг, **1 Кор.** 13:7. Абрахам тэвчээртэй тэсвэрлэсний дараа, тэрээр амлалтыг олж авав, **Евр.** 6:15. Хэрэв тэд эцсээ хүртэл тэвчвээс тэд хожмын өдөр өргөмжлөгдөх болно, **1 Ниф.** 13:37. Хэрэв та

нар зарлигуудад дуулгавартай байж мөн эцсийг хүртэл тэвчвээс, та аврагдах болно, **1 Ниф.** 22:31 (Алма 5:13). Хэрэв та нар урагш тэмүүлэн, Христийн үгнээс зооглон, мөн эцсээ хүртэл тэвчих аваас та нарт мөнх амьдрал байх болно, **2 Ниф.** 31:20 (3 Ниф. 15:9; С ба Г 14:7). Миний нэрийг өөр дээрээ авч, мөн эцсээ хүртэл тэвчих хэн боловч аврагдах болно, **3 Ниф.** 27:6. Эцсээ хүртэл тэвчдэг миний сүмийн хэнийг боловч, түүнийг би өөрийн хадан дээр үндэслэх болно, **С ба Г** 10:69. Итгэлд тэсвэрлэдэг тэрээр дэлхийг ялан дийлэх болно, **С ба Г** 63:20, 47. Есүс Христийн сайн мэдээний төлөө зоригтойгоор тэвчсэн тэд бүгдэд бүх хаан сэнтий хийгээд эзэгнэлүүд танилцуулагдах болно, **С ба Г** 121:29.

ТЭВЧЭЭР. Номхон дөлгөөн,
Номхон дөлгөөн байдал;
Тэвчихийг *мөн үз*

Тайван тэвчээртэй байдал; зовлон, доромжлол буюу гэмтэл бэртлийг гомдон бухимдах буюу хариу үйлдэл үзүүлэлгүйгээр тэвчих чадвар.

ЭЗЭН дотор амарч, түүнийг тэвчээртэйгээр хүлээ, **Дуул.** 37:7–8. Уурлахдаа удаан хүн маш их ухаантай, **Сур.** үгс 14:29. Та нар өөрсдийн тэвчээрээр амиа олж авна, **Лук** 21:19. Судруудын тэвчээр болон урамшуулалтаар дамжуулан бидэнд найдвар байх юм, **Ром** 15:4. Итгэл хийгээд тэвчээрээр дамжуулан амлалтуудыг өвлөгч тэдний дагалдагчид байгтун, **Евр.** 6:12–15. Тэсвэр хатуужил нь төгс үр дүнтэй байдаг, ийнхүү та нар төгс хийгээд бүрэн бүтэн байж болно, **Иаков** 1:2–4. Та нар Иовын тэсвэр тэвчээрийн тухай сонссон, **Иаков** 5:11. Тэд баяртайгаар мөн тэвчээртэйгээр Их Эзэний бүх хүсэл зоригт захирагдсан билээ, **Моз.** 24:15. Их Эзэн чамтай байсан учраас чи эдгээр бүх зүйлийг тэвчээртэйгээр давж чадсан, **Алма** 38:4–5. Та нар төгөлдөржих хүртлээ тэвчээрт үргэлжлүүл, **С ба Г** 67:13.

ТЭМДЭГ. Гайхамшиг; Үнэн сүмийн тэмдэг; Цаг хугацааны тэмдгүүдийг *мөн үз*

Ямар нэг зүйлийн нотолгоо буюу баталгаа байх ёстой хэмээн хүмүүс ойлгодог үйл явдал буюу тохиолдол. Тэмдэг нь ихэнхдээ Бурханаас ирэх гайхамшигт тунхаглал юм. Тэрчлэн Сатан зарим нөхцөлд тэмдгүүд үзүүлэх хүчтэй. Гэгээнтнүүд Сүнсний бэлгүүдийг хайх ёстой боловч сониуч зангаа хангах буюу итгэлээ батлахын тулд тэмдгүүдийг хайх ёсгүй. Итгэдэг хүмүүст тохирохыг нь харж байж Их Эзэн тэмдгүүдийг өгөх болно (С ба Г 58:64).

Их Эзэн өөрөө чамд тэмдгүүдийг өгөх болно, **Иса.** 7:14 (2 Ниф. 17:14). Бурхан тэнгэрт хийгээд дэлхийд тэмдгүүд болон гайхамшгуудаар ажилладаг, **Дан.** 6:27. Хорон муу болоод завхай үеийнхэн тэмдгийг эрж хайдаг, **Мат.** 12:39 (Мат. 16:4; Лук 11:29). Итгэгчдэд энэ тэмдгүүд дагалдана, **Марк** 16:17 (Морм. 9:24, Ифер 4:18; С ба Г 84:65). Шерем тэмдгийг шаардсан, **Иаков** 7:13–20. Корихор тэмдгүүдийг шаардсан билээ, **Алма** 30:48–60. Бидэнд тэмдгүүдийг үзүүл, тэгээд бид итгэх болно, **Алма** 32:17. Хүмүүсийн ихэнх хэсэг нь тэмдгүүд хийгээд гайхамшгуудад итгэж байв, **3 Ниф.** 1:22. Хүмүүс тэмдгүүд хийгээд гайхамшгуудыг мартав, **3 Ниф.** 2:1. Итгэлийн тань сорилтын дарааг хүртэл та нар гэрчийг үл хүлээн авна, **Ифер** 12:6. Намайг зарлиглахаас өөрөөр гайхамшгийг бүү шаард, **С ба Г** 24:13. Итгэл тэмдгийг дагадаггүй, харин тэмдэг нь итгэчийг дагадаг, **С ба Г** 63:7–11. Тэдгээр өдрүүдэд хуурамч Христ, мөн хуурамч бошиглогчид гарч ирнэ, мөн агуу тэмдгүүд хийгээд гайхамшгуудыг үзүүлэх болно, **ИС—Мат.** 1:22.

ТЭНГЭР. Бурханы хаант улс буюу Тэнгэрийн хаант улс; Диваажин; Селестиел алдар сууг *мөн үз*

Тэнгэр гэдэг нэр томьёо нь судруудад үндсэн хоёр утгатай. 1) Энэ бол

Бурханы амьдардаг, мөн Гэгээнтнүүдийн ирээдүйн гэр болох газар мөн (Эхл. 28:12; Дуул. 11:4; Мат. 6:9). 2) Энэ бол дэлхийн орчин дахь огторгуйн уудам мөн (Эхл. 1:1, 17; Ег. 24:10). Тэнгэр бол энэ дэлхий дээр амьдардаг болон нас барсан итгэлтэй тэдний сүнснүүдийн хувьд түр хугацаанд амрах газар болох диваажин биш нь тодорхой юм. Есүс загалмай дээр нас эцэслэсний дараа диваажинд очсон хэдий ч тэрээр Эцэгт хараахан очоогүй тухайгаа Мариад гурав дахь өдөрт мэдээлжээ (Лук 23:39–44; Иохан 20:17; С ба Г 138:11–37).

Таны мутрын бүтээл болох тэнгэрүүдийг би тунгаан бодно, **Дуул.** 8:3. Эзэний үгээр тэнгэрүүд бүтээгдсэн, **Дуул.** 33:6. Аяа, Үүрийн Хүү, чи яаж тэнгэрээс унав аа! **Иса.** 14:12 (2 Ниф. 24:12). Тэнгэр хуйлмал ном мэт хуйлагдах болно, **Иса.** 34:4. Би шинэ тэнгэр, шинэ газрыг бүтээнэ, **Иса.** 65:17. Бурхан тэнгэрийн цонхыг нээх болно, **Малах.** 3:10. Тэнгэр дэх бидний Эцэг минь, таны нэр ариунаар дуурсагдах, **Мат.** 6:9 (3 Ниф. 13:9). Паул гурав дахь тэнгэрт аваачигдав, **2 Кор.** 12:2. Тэнгэрт чив чимээгүй байв, **Илч.** 8:1 (С ба Г 88:95–98). Хэрэв төгсгөл хүртэл итгэлтэйгээр тэсвэл, тэд тэнгэрт хүлээн авагдах болно, **Моз.** 2:41. Та нар тэнгэр дэх Эцэгийнхээ хүүхдүүд байж болно, **3 Ниф.** 12:45. Би тэнгэрийн үүлэн дунд ирэх болно, **С ба Г** 45:16. Елиа үхлийг үзэлгүйгээр тэнгэрт аваачигдсан болой, **С ба Г** 110:13. Санваарын эрхүүд тэнгэрийн хүчнүүдтэй холбогдсон билээ, **С ба Г** 121:36. Тэнгэрт хоёр төрлийн биес буй, **С ба Г** 129:1. Сион тэнгэрт аваачигдсан болой, **Мосе** 7:23.

ТЭНГЭР ДЭХ ДАЙН. Мөнх бус байдлын өмнөх амьдрал; Тэнгэр дэх Зөвлөгөөнийг *мөн үз*

Мөнх бус байдлын өмнөх амьдрал Бурханы сүнсэн хүүхдүүдийн дунд болсон зөрчилдөөн.

Сатан тэнгэрээс газарт хаягдсан байв, **Илч.** 12:4, 7–9. Чөтгөр болон тэнгэрийн гуравны нэг хэсэг доош хаягдсан, **С ба Г** 29:36–37. Люцифер Төрсөн Ганц Хүүг эсэргүүцсэн билээ, **С ба Г** 76:25–26. Эцэгийн алдар суу болон хүний эрх чөлөөг устгахыг Сатан эрхлхийлсэн юм, **Мосе** 4:1–4 (Иса. 14:12–15; Абр. 3:27–28). Бурханыг дагаж анхны байдлаа хадгалсан тэдгээр хүмүүс дэлхийд ирж бие махбодийг хүлээн авсан билээ, **Абр.** 3:26.

ТЭНГЭР ДЭХ ЗӨВЛӨГӨӨН.

Гэтэлгэлийн төлөвлөгөө; Мөнх бус байдлын өмнөх амьдрал; Тэнгэр дэх дайныг *мөн үз*

Мөнх бус байдлын өмнөх амьдралд энэ дэлхийд ирэх сүнсний хүүхдүүддээ Эцэг өөрийн төлөвлөгөөг танилцуулжээ.

Бурханы хүүхдүүд баярлалдан уухайлсан, **Иов** 38:7. Миний сэнтийг Бурханы оддын дээр босгоно, **Иса.** 14:12–13. Тэнгэрт дайн болж байв, **Илч.** 12:7–11. Төрөхөөсөө өмнө тэд анхныхаа хичээлийг сүнсний дэлхийд хүлээн авсан болой, **С ба Г** 138:56. Мөнх бус байдлын өмнөх амьдралд Сатан бослого гаргасан болой, **Мосе** 4:1–4. Дэлхий бүтээгдэхээс өмнө оюун билиг зохион байгуулагдах, **Абр.** 3:22. Бурхад хоорондоо зөвлөлдөв, **Абр.** 4:26. Бурхад хийхээр зөвлөлдсөн ажлаа дуусгав, **Абр.** 5:2.

ТЭНГЭР ДЭХ ЭЦЭГ. Бурхан, Бурхан Тэргүүтнийг *мөн үз*

Бүх хүмүүн төрөлхтний сүнсний Эцэг (Дуул. 82:6; Мат. 5:48; Иохан 10:34; Ром 8:16–17; Гал. 4:7; 1 Иохан 3:2). Есүс бол маханбодид төрсөн түүний Төрсөн Ганц Хүү мөн. Эцэгийг дуулгавартай дагаж, дээдлэн хүндэлж, мөн Есүсийн нэрээр түүнд залбирч байхыг хүмүүнд зарлигласан билээ.

Хэрэв та нар хүмүүсийг уучилбал, Тэнгэрлэг Эцэг тань та нарыг мөн

уучилна, **Мат.** 6:14 (**Мат.** 18:35; 3 Ниф. 13:14). Эдгээр бүх зүйлүүд та нарт хэрэгтэй гэдгийг Тэнгэрлэг Эцэг тань мэддэг билээ, **Мат.** 6:26–33 (3 Ниф. 13:26–33). Тэнгэрлэг Эцэг тань өөрөөс нь гуйдаг хүмүүст Ариун Сүнийг хичнээн ихээр өгөх билээ, **Лук** 11:11–13. Бидний Эзэн Есүс Христийн Эцэг ба Бурхан магтагдах болтугай, **Ефес** 1:3. Та нар Тэнгэрлэг Эцэгтээ мөнхийн өртэй билээ, **Моз.** 2:34. Христ Эцэгийн нэрийг алдаршуулав, **Ифер** 12:8. Гэгээнтнүүд өөрсдийг нь мөрдөн хавчиж байгаа тухай Бурханы өмнө, нуугдаж байгаа газраасаа түүнийг урагш гарч ирэхэд нь гэрчлэх ёстой, **С ба Г** 123:1–3, 6. Бид Тэнгэрлэг Эцэгээсээ агуу хийгээд алдар суут адислалыг хүртсэн билээ, **ИС—Т** 1:73.

ТЭНГЭР ЭЛЧҮҮД

Сүнсэн мөн мах хийгээд ясан биетэй тэнгэр элчүүд хэмээн нэрлэгддэг хоёр хэлбэрийн хүмүүн биес тэнгэрт байдаг. Тэнгэр элчүүд нь мах хийгээд ясан биенийг олж аваагүй буюу мөнх бус амьдралд урьд нь байсан, түүнчлэн амилуулалтыг хүлээж буй сүнснүүд байдаг. Мах хийгээд ясан биетэй тэнгэр элчүүд нас барагсдаас амилуулагдсан буюу зөөгдсөн байдаг.

Тэнгэр элчүүдийн ажлын олон ишлэл сударт байдаг. Бурханы захиасыг түгээхдээ тэнгэр элчүүд заримдаа аянгын дуу хоолойгоор ярьдаг (**Моз.** 27:11–16). Зөв шударга мөнх бус хүмүүсийг мөн тэнгэр элч хэмээн дууддаг (**ИСО,** **Эхл.** 19:15). Зарим тэнгэр элчүүд тэнгэрт Бурханы сэнтийн дэргэд үйлчилдэг (**Алма** 36:22).

Судрууд мөн чөтгөрийн элчүүдийн тухай өгүүлдэг. Тэдгээр нь Люсиферийг даган мөнх бус амьдралын өмнөх амьдралд Бурханы дэргэдээс зайлуулагдан, дэлхий дээр хаягдсан сүнснүүд юм (**Илч.** 12:1–9; 2 Ниф. 9:9, 16; **С ба Г** 29:36–37).

Бурханы тэнгэр элчүүд өгсөн уруудан байхыг Иаков харжээ, **Эхл.**

28:12. Бурханы тэнгэр элч Иаковтай уулзав, **Эхл.** 32:1–2. Гидеон Бурханы тэнгэр элчийг нүүр нүүрээрээ тулан харжээ, **Шүүгч** 6:22. Тэнгэр элч Иерусалимын дээгүүр гараа сунган түүнийг устгав, **2 Сам** 24:16. Тэнгэр элч Елиад хүрч түүнд, Бос мөн ид хэмээн хэлэв, **Хаад.** дээд 19:5–7. Даниел тэнгэр элч Габриелийг үзэгдэлд харжээ, **Дан** 8:15–16. Тэнгэр элч Михаил Даниелд тусалжээ, **Дан** 10:13. Тэнгэр элч Габриел Бурханаас илгээгдсэн болой, **Лук** 1:19, 26–27. Чөтгөрийн элчүүдийг шүүлт хүртэл хүлээстэй нь хорьжээ, **Иуд.** 1:6 (2 Петр 2:4). Тэнгэр элчүүд тэнгэрээс бууж ирж байгааг хүмүүс харав, **3 Ниф.** 17:24. Моронай тэнгэр элчийн тохинууллын тухай бичив, **Моро.** 7:25–32. Аароны санваартнууд тэнгэр элчийн тохинууллын түлхүүрүүдийг атгадаг, **С ба Г** 13. Моронай, Иохан Баптист, Петр, Иаков, Иохан, Мосе, Елиа мөн Елиас нар Иосеф Смитэд тэнгэр элчийн дүрээр тохинуулав, **С ба Г** 27:5–12. Та нар тэнгэр элчийн тохинуулалд оршиж чадах нь үггүй, **С ба Г** 67:13. Михаил, тэргүүн тэнгэр элч бол Адам, **С ба Г** 107:54. Тэнгэр элчүүд нь мах хийгээд ясан биетэй хүн юм, **С ба Г** 129. Үүнд харьяалагдахаас өөр энэ дэлхийд тохинуулдаг тэнгэр элч гэж үгүй, **С ба Г** 130:5. Бурханы мөнхийн гэрлэлтийн хуулийг дагадаггүй хүмүүнд гэрлэх нь, эсвээс хадамд гарах нь ч өгөгдөөгүй, харин тэнгэр дэх тэнгэр элчүүдээр томилогддог буюу, **С ба Г** 132:16–17.

ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГ. Бурхан,
Бурхан Тэргүүтэн; Тэнгэр дэх
Эцэгийг үз

ТЭРГҮҮЛЭХ БИШОП

Сүм дэх ерөнхий эрх мэдэлтэн. Тэрээр Сүмийн материаллаг хангамжийн талаар ерөнхий үүрэг хариуцлага хүлээдэг (**С ба Г** 107:68). Мөн тэрчлэн Ерөнхий Эрх Мэдэлтнүүд болох Тэргүүлэх бишоп хийгээд түүний зөвлөхүүд Сүмийн

Аароны санваартнуудыг тэргүүлдэг (С ба Г 68:16–17; 107:76, 87–88).

Эдвард Партриж бишпоор томилогдох ёстой, **С ба Г 41:9**. Бишпоууд нь Тэргүүн Зөвлөлөөр дуудагдаж мөн онцгойлон адислагддаг байх ёстой, **С ба Г 68:14–15**. Ууган төрөгсөд болох Аароны шууд удмынхан, хэрэв Тэргүүн Зөвлөлөөр дуудагдаж, онцгойлон адислагдаж мөн томилогдох аваас тэргүүлэх эрхтэй байна, **С ба Г 68:16, 18–20**. Зөвхөн Тэргүүн Зөвлөлийн өмнө шүүгддэг байж болно, **С ба Г 68:22–24** (С ба Г 107:82).

ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛ. Санваарын түлхүүрүүд; Ерөнхийлөгч; Илчлэлтийг мөн үз

Сүмийн Ерөнхийлөгч болон түүний Зөвлөхүүд. Тэд гурван дээд санваартны чуулга болдог бөгөөд Сүмийг нийтэд нь тэргүүлдэг. Тэргүүн Зөвлөл санваарын бүх түлхүүрүүдийг атгадаг.

Хаант улсын түлхүүрүүд ямагт Дээд санваартны Ерөнхийлөгчийн Зөвлөлд харьяалагддаг, **С ба Г 81:2** Дээд санваартны Ерөнхийлөгчийн Зөвлөл нь бүх албан тушаалуудад ажиллах эрхтэй, **С ба Г 107:9, 22**. Намайг хүлээн авдаг хэн боловч Тэргүүн Зөвлөлийг хүлээн авдаг, **С ба Г 112:20, 30**. Нийт Сүмийн хувьд үгсийг [илчлэлтүүдийг] Тэргүүн Зөвлөл хүлээн авах ёстой, **С ба Г 124:126**.

ТЭРГҮҮН ТЭНГЭР ЭЛЧ. Адам; Михайлыг мөн үз

Михаил буюу Адам бол тэргүүн тэнгэр элч буюу ерөнхий тэнгэр элч юм.

Их Эзэн тушаалын үгтэй, тэргүүн тэнгэр элчийн дуу хоолойтой тэнгэрээс бууж ирнэ, **1 Тес. 4:16**. Михаил бол тэргүүн тэнгэр элч, **Иуда 1:9** (С ба Г 29:26; 88:112; 128:20–21).

УГААГДСАН, УГААЛГА, УГААХ.

Баптисм, Баптисм хүртээх; Цагаатгал, Цагаатгахыг мөн үз

Бие махбодиороо буюу сүнсээр цэвэрших. Бэлэгдлээр бол, Есүс

Христийн цагаатгагч золиослолоор дамжуулан наманчилдаг хүн нүглээр хүндэрсэн амьдрал болон үүний үр дагавруудаас цэвэршигдэж болно. Зарим угаалга санваарын зохих эрх мэдлээр ариун нандин ёслолууд болон гүйцэтгэгддэг.

Санваартан хувцсаа угаан, өөрийн биеийг усанд булхаж ёстой, **Тоол. 19:7**. Гэм буруугаас минь намайг гүйцэд угаа, **Дуул. 51:2, 7**. Биесээ угаагтун, өөрсдийгөө цэвэрлэ, нүгэл үйлдэхээ боль, **Иса. 1:16–18**. Есүс Төлөөлөгчдийнхөө хөлийг угаав, **Иохан 13:4–15** (С ба Г 88:138–139). Баптисм хүртэж, нүглүүдээ угаа, **Үйлс 22:16** (Алма 7:14; С ба Г 39:10). Өмсгөл нь цагаанаар угаагдахаас бусдаар өөр хэн ч аврагдаж чадах нь үгүй, **Алма 5:21** (3 Ниф. 27:19). Тэдний өмсгөлүүд нь Христийн цусаар дамжин цагаанаар угагдсан байв, **Алма 13:11** (Ифер 13:10). Зарлигуудыг дагаснаар тэд бүх нүглээсээ цэвэршигдэн угаагдах болно, **С ба Г 76:52**. Чиний тосолгоо хийгээд чиний угаалга миний ариун өргөөний ёслолуудаар томилогдсон болой, **С ба Г 124:39–41**.

УДМЫН БИЧИГ. Аврал; Баптисм, Баптисм хүртээх—Нас барагсдын төлөөх баптисм; Гэр бүл; Дурсамжийн ном; Ёслолууд—Төлөөлөн хийлгэх ёслолууд; Нас барагсдын авралыг мөн үз

Гэр бүлийн удам угсааг харуулдаг цэдэг. Судрууд дахь тодорхой нэг гэр бүлийн санваарын албан тушаалууд буюу зарим адислалууд хязгаарлагдмал удмын бичгүүд маш чухал ач холбогдолтой юм (Эхл. 5; 10; 25; 46; Шаст. дээд 1–9; Езра 2:61–62; Нех. 7:63–64; Мат. 1:1–17; Лук 3:23–38; 1 Ниф. 3:1–4; 5:14–19; Жером 1:1–2). Өнөөдөр сэргээгдсэн Сүмд Сүмийн гишүүд нас барсан өвөг дээдсээ сайн мэдэж авахын тулд, өвөг дээдсийнхээ өмнөөс аврах ёслолуудыг гүйцэтгэхийн тулд, гэр бүлийнхээ удмын бичгийг үргэлжлүүлэн хөтөлдөг билээ. Эдгээр

ёслолууд нь Сүнсний ертөнцөд Есүс Христийн сайн мэдээг хүлээн авдаг нас барагсдын хувьд хүчин төгөлдөр байдаг (С ба Г 127, 128).

УЛААН ӨНДӨГНИЙ БАЯР. Есүс
Христийн Амилалтыг үз

УЛААН ТЭНГИС. Мосег *мөн үз*

Египет Арабын хоорондох усан тогтоц. Улаан Тэнгисийн умард хоёр булан Синайн хойгийн эргийн дагуух зурвасыг бүрдүүлдэг. Израилчууд Мосегийн удирдлаган дор Улаан Тэнгисийг гатлан хуурай газарт гарахын тулд Их Эзэн гайхамшигтайгаар тэнгисийг хуваажээ (Ег. 14:13–31; Евр. 11:29). Мосе тэнгисийг таллан хуваасан нь хожмын үеийн илчлэлтэд нотлогддог (1 Ниф. 4:2; Хил. 8:11; С ба Г 8:3; Мосе 1:25).

УМБУУЛАЛТ. Баптисм, Баптисм
хүртээх; Умбуулалтаар
баптисм хүртээхийг үз

УР

Хуучин Гэрээнд, Халдеин Ур нь Абрамын уугуул нутаг байв (Эхл. 11:27–28, 31; 15:7; Нех. 9:7; Абр. 2:1, 4).

УРВАЛТ. Эсэргүүцэл; Сайн
Мэдээний Сэргээлтийг *мөн үз*

Хувь хүмүүс, Сүм болон бүхэл үндэстнээрээ үнэнээс нүүр буруулах.

Нийтийг хамарсан урвалт: Израил тэдний зүрх сэтгэл Их Эзэнээсээ нүүр буруулахын эсрэг сэрэмжлэх ёстой, **Дэд хууль** 29:18. Үзэгдэл үгүй бол хүмүүс эрсдэнэ, **Сур. үг.** 29:18. Тэд үүрдийн гэрээг эвдэв, **Иса.** 24:5. Салхи тэр байшинг нүдсэнд энэ нь нурав, **Мат.** 7:27. Би чамайг өөр сайн мэдээ уруу ийм хурдан шилжсэнд гайхаж байна, **Гал.** 1:6. Тэд зөв замаар эхэлсэн боловч тэд мананд замаа алдав, **1 Ниф.** 8:23 (1Ни 12:17). Тэд жимснээс амссаныхаа дараа тэд хориглогдсон зам уруу төөрөлджээ, **1 Ниф.** 8:28. Нифайчуудын урвалт үл итгэгчийн

бүдрэлийн чулуу болжээ, **Алма** 4:6–12. Сүмийн олон гишүүн бардам болж мөн бусад гишүүдийг мөрдөн хавчив, **Хил.** 3:33–34 (Хил 4:11–13; 5:2–3). Их Эзэн өөрийнхөө хүмүүсийг цэцэглүүлэн хөгжүүлэхэд, заримдаа тэд зүрх сэтгэлээ хатууруулж мөн түүнийг мартдаг, **Хил.** 12:2; 13:38. Нифайчууд зүрх сэтгэлээ хатууруулж мөн Сатаны хүчин дор унажээ, **3 Ниф.** 2:1–3. Хожмын өдрүүд дэх урвалтын тухай Моронай бошиглов, **Морм.** 8:28, 31–41. Дахин Ирэлтийн өмнө урвалт болно, **С ба Г** 1:13–16.

Эртний Христийн сүмийн урвалт: Энэ хүмүүс амаараа надтай ойр байдаг, **Иса.** 29:10, 13. Дэлхийг харанхуй нөмрөх болно, **Иса.** 60:2. Их Эзэн өлсгөлөнгийн мөндөр илгээх болно гэсэн нь Их Эзэний үг, **Амос** 8:11. Хуурамч Христүүд болон хуурамч бошиглогчид гарч ирэх болно, **Мат.** 24:24. Сүргийг үл энэрэх догшин чононууд та нарын дунд орж ирэх болно, **Үйлс** 20:29. Та нар түүнээс ийм хурдан салж байгаад би гайхаж байна, **Гал.** 1:6. Дахин Ирэлтийн өмнө итгэлээс салах явдал гарах болно, **2 Тес.** 2:3. Зарим хүмүүс үнэний хувьд алдаж байв, **2 Тим.** 2:18. Зарим хүмүүс бурханлиг байдлын дүртэй байх боловч түүний хүчийг үгүйсгэдэг, **2 Тим.** 3:5. Тэд зөв сайн мэдээг тэвчихгүй болох цаг ирнэ, **2 Тим.** 4:3–4. Хүмүүсийн дунд хуурамч бошиглогчид болон хуурамч багш нар байх болно, **2 Петр** 2:1. Зарим хүмүүс цорын ганц Их Эзэн Бурханыг үгүйсгэхээр шургалан орж иржээ, **Иуд.** 1:4. Зарим хүмүүс тэнд Төлөөлөгч байсан гэж хэлэх ба энэ нь үгүй билээ, **Илч.** 2:2. Нифай агуу хийгээд жигшүүрт сүмийн үүслийг харжээ, **1 Ниф.** 13:26. Харийнхан бүдэрч мөн олон сүмийг барьжээ, **2 Ниф** 26:20. Тэд миний ёслолуудаас нүүр бууруулж, мөн миний үүрдийн гэрээг зөрчсөн билээ, **С ба Г** 1:15. Харанхуй нь дэлхийг, мөн тунэр харанхуй нь хүмүүсийн оюуныг бүрхжээ, **С ба Г** 112:23. Сүмүүд бүгд

буруу бөгөөд тэдний зүрх сэтгэл Бурханаас хол хэмээн Иосефт хэлжээ, **ИС—Т 1:19**.

УРГАЦ ХУРААЛТ

Судруудад заримдаа ургац хураалт гэдэг үгийг дэлхий дээрх Бурханы хаант улс болох Сүмд хүмүүсийг авчрахад, эсвээс шүүлтийн үед, түүнчлэн Есүс Христийн хоёр дахь ирэлт мэтгэй зүйрлэсэн байдаг.

Ургац хураалт өнгөрч, зун дууссан бөгөөд бид аврагдаагүй байна, **Иер. 8:20** (С ба Г 56:16). Ургац арвин боловч, ажилчид нь цөөн байна, **Мат. 9:37**. Ургац нь дэлхийн төгсгөл юм, **Мат. 13:39**. Хүн юу тарина, түүнийгээ л хурааж авдаг, **Гал. 6:7–9** (С ба Г 6:33). Талбай нь цагаан, аль хэдийн хадахад бэлэн байна, **С ба Г 4:4**. Ургац хураалт дуусч мөн та нарын бодгалиуд аврагдсан нь үгүй, **С ба Г 45:2**. Ургац хураалтын цаг ирж мөн миний үг биелэгдэх ёстой, **С ба Г 101:64**.

УРИМ БА ТУММИМ. Үзмэрч;

Цээжний хуягийг *мөн үз*

Илчлэлт олж авах хийгээд хэлнүүдийг орчуулахад нь хүнд туслахаар Бурханы бэлтгэсэн зэмсэг. Еврей хэлэнд энэ үг нь “гэрлүүд ба төгөлдөржилт” гэсэн утгатай. Урим ба Туммим нь мөнгөн нуманд суулгасан хоёр чулуу бөгөөд заримдаа цээжний хуягтай хамт хэрэглэгддэг байв (С ба Г 17:1; **ИС—Т 1:35, 42, 52**). Ариусгагдсан хийгээд үхэшгүй байдалдаа энэ дэлхий агуу их Урим ба Туммим болох болно (С ба Г 130:6–9).

Шүүлтийн цээжний хуяг дотор Урим ба Туммимыг хий, **Ег. 28:30**. Ялсан түүнд нь би цагаан чулууг өгөх болно, **Илч. 2:17**. Түүнд харж мөн орчуулж чадах зүйл байв, **Моз. 8:13**. Энэ хоёр чулууг чамд өгөх болно, **Ифер 3:23–24, 28** (Ифер 4:5). Иосеф Смит илчлэлтийг Урим ба Туммимаар хүлээн авчээ, **С ба Г бүлэг 6, 11, 14–16-ын** Толгой гарчгууд). Чамд Урим ба Туммимыг ашиглан

орчуулах хүч байсан, **С ба Г 10:1**. Гурван гэрч Жаредын ахад өгсөн Урим ба Туммимаар харах болно, **С ба Г 17:1**. Бурханы оршин суух газар бол агуу Урим ба Туммим юм. Цагаан чулуу нь хүн бүр нэгийг хүлээн авах Урим ба Туммим болох болно, **С ба Г 130:6–11**. Абрахам надад Урим ба Туммим байсан, **Абр. 3:1, 4**.

УРУУ ТАТАЛТ, УРУУ ТАТАХ.

Сонгох эрх; Тэвчих; Чөтгөрийг *мөн үз*

Хилэнцэгийн оронд сайныг сонгох хүний чадварын сорилт; нүгэл үйлдэхэд түүнчлэн Бурханы оронд Сатаныг дагахад уруу татах.

Биднийг сорилтод бүү оруулаач, харин бузар муугаас гэтэлгээч, **Мат. 6:13** (3 Ниф. 13:12). Бурхан та нарыг хэрээс чинь хэтэрсэн хүчээр соригдохыг зөвшөөрөхгүй, **1 Кор. 10:13**. Христ бидний адил соригдсон юм, **Евр. 4:14–15**. Сорилтыг тэсвэрлэдэг хүн адислагдсан юм, **Иаков 1:12–14**. Бурханы үгийг сондог тэднийг хортны уруу таталтууд давамгайлж чадах нь үгүй, **1 Ниф. 15:24** (Хил. 5:12). Хүн хэн нэгнээр эсвээс нөгөөгөөр уруу татагдсан байхаас бусдаар, өөрийнхөө төлөө үйлдэж чадахгүй, **2 Ниф. 2:11–16**. Та нар өөрсдийн үүрч чадахаас илүүгээр уруу таталтанд автагдахгүйн тулд үргэлж сэрэмжилж мөн залбираасай, **Алма 13:28**. Чөтгөрийн уруу таталт болгоныг Их Эзэн Есүс Христэд итгэх өөрсдийн итгэлээр сөрөн зогсохыг тэдэнд заа, **Алма 37:33**. Уруу таталтанд орохгүйн тул үргэлж залбир, **3 Ниф. 18:15, 18** (С ба Г 20:33; 31:12; 61:39). Уруу таталтанд орохгүйн тул бардамналаас болгоомжил, **С ба Г 23:1**. Адам уруу таталданд автагдсан учир тэрээр чөтгөрийн хүсэл зоригт захирагдсан бөлгөө, **С ба Г 29:39–40**. Бибээр олон төрлийн уруу таталтуудад орж байв, **ИС—Т 1:28**.

УРЬДЧИЛАН ТОДОРХОЙЛОХ.

Урьдчилсан томилолтыг үз

УРЬДЧИЛСАН ТОМИЛОЛТ.

Мөнх бус байдлын өмнөх амьдралыг *мөн үз*

Хүчирхэг сүнстэй өөрийн хүүхдүүдийг тэдний мөнх бус амьдралын үед тодорхой ажил үүргийг гүйцэлдүүлэхээр мөнх бус байдлын өмнөх үед Бурхан урьдчилан томилох.

Бурхан ард түмний хил хязгаарыг тогтоожээ, **Дэд хууль** 32:8. Эхийн хэвлийд чамайг бүрдүүлэхээсээ өмнө би чамайг эш үзүүлэгч болгон томилсон, **Иер.** 1:5. Томилохоос нь өмнө Бурхан цаг хугацааг тогтоосон, **Үйлс** 17:26. Урьдаас мэдсэн хүмүүсээ тэр бас урьдаас тогтоосон юм, **Ром** 8:28–30. Тэрээр ертөнцийн сууринаас урьд биднийг өөрийнхөө дотор сонгосон юм, **Ефес** 1:3–4. Есүс Христ Гэтэлгэгч байхаар урьдчилан сонгогдсон байлаа, **1 Петр** 1:19–20 (Илч. 13:8). Тэд дэлхийн үүслээс дуудагдаж, мөн бэлтгэгдсэн байв, **Алма** 13:1–9. Эхлэлд сонгогдсон тэдгээр сурвалжит хийгээд агуу их хүмүүсийг би ажиглав, **С ба Г** 138:55–56. Миний Хайртай Хүү эхлээс сонгогдсон байв, **Моце** 4:2. Абрахам төрөхөөсөө өмнө сонгогдов, **Абр.** 3:23.

УСТГАГЧ. Чөтгөрийг *мөн үз*

Сатан бол устгагч.

Их Эзэн та нарын гэрт устгагчид орохыг зөвшөөрөхгүй, **Ег.** 12:23. Устгагч их усан дээгүүр гүйдэг, **С ба Г** 61:19. Харуул миний усан үзмийн цэцэрлэгийг устгагчаас хамгаалж чадах байсан, **С ба Г** 101:51–54.

УУГАН. Есүс Христ; Өв

залгамжлах эрхийг *мөн үз*

Эртний патриархын үед ууган хүү өв залгамжлах эрхийг хүлээн авдаг байсан бөгөөд (Эхл. 43:33) тийнхүү эцгийгээ нас барахад гэр бүлийг тэргүүлэх явдлыг залгамжлан авдаг байв. Ууган хүү энэ үүрэг хариуцлагад дүйцэхүйц зохистой байх ёстой бөгөөд (Шаст. дээд 5:1–2) мөн зөв шударга биш байснаар өв залгамжлах эрхээ алдаж болдог байв.

Мосегийн хуулиар, ууган хүү Бурханд харьяалагддаг гэж үздэг байв. Ууган хүү эцгийнхээ эзэмшдэг хөрөнгөнөөс бусад хөвгүүдэд ногдох хувиас хоёр дахин ихийг авдаг байжээ (Дэд хууль 21:17). Эцгээ нас барсны дараа тэр ээж болон эгч, эмэгтэй дүү нарынхаа төлөө санаа тавих хариуцлагыг хүлээдэг байв.

Мөн үүнчлэн ууган эр төл Бурханд харьяалагддаг байв. Өө сэвгүй цэвэр малыг тахил өргөхөд ашигладаг байсан бол, цэвэр биш малыг гэтэлгэх, худалдах буюу эсвэл нядалдаг байлаа (Ег. 13:2, 11–13; 34:19–20; Лев. 27:11–13, 26–27).

Ууган нь Есүс Христ, дэлхий дээрх түүний тохинууллыг бэлэгддэг бөгөөд агуу Мессиа ирэх болно гэдгийг хүмүүст сануулдаг байв (Моце 5:4–8; 6:63).

Есүс бол бидний Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүдийн ууган нь, махан биед төрсөн Эцэгийн Төрсөн Ганц бөгөөд нас барагсдаас амилалтад анх боссон нь билээ (Кол. 1:13–18). Итгэлтэй Гэгээнтнүүд үүрд мөнхөд Ууган Хүүгийн Сүмийн гишүүд болдог (С ба Г 93:21–22).

Хөвгүүдийнхээ ууганыг нь чи надад өгөх ёстой, **Ег.** 22:29. Израилын бүх ууган төрөгсдийг би өөртөө ариусгасан, **Тоол.** 3:13. Тэрээр олон ах дүүсийнхээ дунд ууган нь байж болох билээ, **Ром** 8:29. Ууган төрсөн түүнийг тэрээр дэлхийд авчвар, **Евр.** 1:6. Тэд бол Ууган Хүүгийн Сүмийн хүмүүс билээ, **С ба Г** 76:54, 94. Бүр ууган хүүгийн эрх эцгүүдээс надад олгогдсон билээ, **Абр.** 1:3.

УУЛАН ДЭЭРХ НОМЛОЛ. Ерөөл;

Есүс Христийг *мөн үз*

Номлолд илгээгдэх гэж байсан шавь нартаа Их Эзэн Есүс Христийн хэлсэн үг (Мат. 5–7; Лук 6:20–49). Арванхоёрыг дуудсаныхаа дараа удалгүй Их Эзэн энэ номлолыг өгчээ.

Номлол нь Библийн Иосеф Смитийн орчуулгаар тодорхой болсон бөгөөд Матайн шастираас алдагдсан

номлолын чухал хэсгийг харуулсан үүнтэй төстэй номлолыг 3 Нифай 12–14-т цэдэглэжээ.

УУР. Үзэн ядалт, Үзэн ядах;
Хайрыг мөн үз

Уур нь зан авирын илэрхийлэл юм. Их Эзэн өөрийнхөө Гэгээнтнүүдэд уураа хянаж байхыг сануулжээ (Мат. 5:22). Гэр бүлд эцэг эх болон хүүхэд бусадтайгаа зүй бус харьцах ёсгүй. Судруудад ихэнх тохиолдолд уурыг галтай төсөөлөн зүйрлүүлсэн нь олонтаа тохиолддог (2 Ниф. 15:25; С ба Г 1:13).

Мөн Каин ихэд уурлан мөн тэрээр уруу царайлав, **Эхл.** 4:5. Их Эзэн уурлахдаа удаан, хайр энэрлээр агуу юм, **Дуул.** 145:8. Эелдэг хариулт уурыг зайлуулдаг, **Сур.** үг. 15:1. Ууртай хүн маргааныг өдөөдөг бол уурлахдаа удаан хүн маргааныг намжаадаг, **Сур.** үгс. 15:18 (Сур. үгс. 14:29). Өөрийнхөө нэрийн төлөө би уур хилэнгээ хойшлуулав, **Иса.** 48:9. Уур минь үргэлжилж байгааг батлахын тулд хүмүүсийн дээгүүр Би гараа сунгасан, **Иса.** 65:2–3. Хэн баруун хацрыг чинь алгадна, түүнд нөгөө хацраа мөн тавьж өг, **Мат.** 5:39. Эцгүүд ээ, хүүхдүүдээ бүү уурлуул, **Ефес** 6:4. Би чамд үнэнийг хэлсэн учраас чи надад ууртай байна, **Моз.** 13:4. Би энэ хүмүүст уур хилэнгээрээ зочлох болно, **Алма** 8:29. Бүх зүйл дээр түүний гарыг хүлээн зөвшөөрдөг түүнээс бусад хүмүүсийн эсрэг түүний хилэнгэл дүрэлзэж байна, **С ба Г** 59:21. Их Эзэн, бибээр ёс бусчуудад уур хүрч байна, **С ба Г** 63:32.

УУЧЛАГДШГҮЙ НҮГЭЛ.

Аллага; Ариун Сүнс;
Доромжлол, Доромжлох;
Мөхлийн хөвгүүдийг мөн үз

Ариун Сүнсийг үгүйсгэх нүгэл, өршөөгдөх боломжгүй нүгэл.

Ариун Сүнсний эсрэг хүмүүний доромжлол уучлагдах ёсгүй, **Мат.** 12:31–32 (Марк 3:29; Лук 12:10).

Ариун Сүнсний хүртэгчид болчихоод гэмшилд дахин шинэчлэгдэх боломжгүй юм, **Евр.** 6:4–6. Хэрэв бид үнэний мэдлэгийг хүлээн авсны дараа санаатайгаар нүгэл үйлдвэл нүглийн төлөөх золиос үлдэхгүй, **Евр.** 10:26. Чи мэдэх атлаа Ариун Сүнсийг үгүйсгэх аваас энэ нь уучлагдашгүй нүгэл юм, **Алма** 39:5–6 (Иаков 7:19). Цорын ганц Хүүг үгүйсгэж, түүнийг өөрсдөө цовдолсон тэдэнд уучлал байхгүй, **С ба Г** 76:30–35. Шинэ бөгөөд үүрдийн гэрээг хүлээн авсныхаа дараа гэмгүй цусыг урсгах нь, мөн түүнчлэн Ариун Сүнсний эсрэг доромжлол нь уучлагдах ёсгүй, **С ба Г** 132:26–27.

УХАМСАР. Гэрэл, Христийн гэрлийг мөн үз

Зөв болон буруу гэсэн дотоод мэдэрэмж Христийн гэрлээс бүх хүмүүсийн дотор ирдэг (Моро. 7:16). Христийн гэрэл хүн бүхэнд өгөгдсөн учраас бид төрөхдөө зөв бурууг ялгах төрөлхийн чадвартай байдаг (С ба Г 84:46). Энэ чадварыг ухамсар гэдэг. Ийм байдаг нь биднийг хариуцлагатай бие хүмүүс болгодог. Бусад чадваруудын нэгэн адил, нүгэл болон буруу ашигласнаас бидний ухамсар мөхөж болно.

Хуулийн багш нар болон фарисайчууд өөрсдийнхөө ухамсарт шийтгүүлсэн, **Иохан** 8:9. Тэдний мөс чанар ч хамт гэрчилдэг, **Ром** 2:14–15. Урвагчид мөс чанартаа халуун төмрөөр тамгалагдсан ажгуу, **1 Тим.** 4:2. Хүмүүн нь тэд сайныг муугаас ялгаж мэдэхээр хангалттай зааварлагдсан бөлгөө, **2 Ниф.** 2:5. Бэнжиман хаан Бурханы өмнө цэвэр ухамсартай байв, **Моз.** 2:15. Нифайчуудын ухамсар амар амгалан байж, баяр баясгалангаар дүүрсэн байв, **Моз.** 4:3. Зиезром өөрийн гэмийг ухамсарласнаар түүний бодгаль тарчилсан буюу, **Алма** 14:6. Бидний хүслийн дагуу ухамсрын баясал болон гэмшил бидэнд өгөгдсөн билээ, **Алма** 29:5. Шийтгэл болон шударга хууль

нь ухамсрын гэмшлийг авчирдаг, **Алма** 42:18. Христийн Сүнс бүх хүмүүнд тэрээр муугаас сайныг мэдэж болохын тулд өгөгдсөн, **Моро**. 7:6. Хувь хүн бүр ухамсраа ашиглах эрхтэй байх ёстой, **С ба Г** 134:2. Хүний мөсөөр гэм зэмгүй байхыг хичээдэг, **С ба Г** 135:4. Бид өөрсдийн ухамсрын сонгох эрх чөлөөний дагуу Бурханыг шүтэн бишрэх эрхийг шаардаж байна, **ИТ** 1:11.

УЯМАН ЯР

Шинэ ба Хуучин Гэрээнүүдэд олонтаа өгүүлэгддэг халдварт өвчин. Библи дэх олон сурвалжит хүмүүс түүний дотор Моше (Ег. 4:6–7) болон түүний эгч Мириам (Тоол. 12:10;) Нааман (Хаад. дэд 5), тэрчлэн Уззиа хаан (Шаст. дэд 26:19–21) уг өвчнөөр зовон шаналж байв.

Есүс нилээд хэдэн хүний уяман ярыг эдгээв, **Мат.** 8:2–4 (Марк 1:40–45; Лук 5:12–15; 3 Ниф. 17:7–9). Есүс уяман яртай арван хүнийг эдгээв, **Лук** 17:11–19.

ҮГ. Есүс Христ—Христийн мөнх бус байдлын өмнөх оршихуйг үз

ҮЗМЭРЧ. Бошиглогч; Урим ба Туммимыг мөн үз

Дэлхийгээс Бурханы нуусан зүйлсийг сүнсний мэлмийгээр харах, Бурханаас эрх мэдэл олгогдсон хүн (Мосе 6:35–38). Тэрээр илчлэгч хийгээд бошиглогч мөн (Моз. 8:13–16). Мормоны Номонд, зөвхөн үзмэрч л онцгой хөрвүүлэгч буюу Урим ба Туммимыг ашиглаж чадна хэмээн Аммон заажээ (Моз. 8:13; 28:16). Үзмэрч нь өнгөрсөн, одоо, ирээдүйг мэддэг. Эрт дээр үед, бошиглогчийг үзмэрч хэмээн олонтаа нэрлэдэг байв (1 Сам. 9:9; 2 Сам. 24:11).

Иосеф Смит бол хожмын үеийн агуу үзмэрч юм (С ба Г 21:1; 135:3). Түүнээс гадна, Тэргүүн Зөвлөл хийгээд Арван хоёрын Зөвлөл бошиглогч, үзмэрч, мөн илчлэгчид хэмээн дэмжигддэг.

Үзмэрчид бүү үзэгдэл үз, эш үзүүлэгчдэд эш үзүүлж болохгүй хэмээгч нь эсэргүүцэгч хүмүүс юм, **Иса.** 30:9–10. Чиний хэвлийн үрсээс сонгогдох үзмэрчийг би өсгөх болно, **2 Ниф.** 3:6–15. Энд мэргэн ухаан буй; тийм ээ, үзмэрч, илчлэгч, орчуулагч мөн бошиглогч байх нь болой, **С ба Г** 107:92. Их Эзэн Хайрум Смитийг Сүмийн бошиглогч, үзмэрч, мөн илчлэгч байхаар томилов, **С ба Г** 124:91–94.

ҮЗЭГДЭЛ. Анхны Үзэгдэл; Зүүд; Илчлэлтийг мөн үз

Ариун Сүнсний хүчээр дамжин ирдэг зарим үйл явдал, хүн буюу юмны талаар харагдах илчлэлт.

Чухал үзэгдлүүдийн жишээнд дараах нь багтдаг: Эцсийн өдрүүдийн талаарх Езекилийн үзэгдэл (Езек. 37–39), Бурханы баруун гар талд Есүс зогсож байгааг харсан Стефений үзэгдэл (Үйлс. 7:55–56), эцсийн өдрүүдийн тухай Иоханы илчлэлт (Илч. 4–21), Амьдралын модны талаарх Лихайн болон Нифайн үзэгдэл (1 Ниф. 8, 10–14), Залуу Алмагийн харсан Их Эзэний тэнгэр элчийн тухай үзэгдэл (Моз. 27), дэлхийн бүх оршин суугчдыг харсан Жаредын ахын үзэгдэл (Ифер 3:25), алдар суунуудын тухай үзэгдэл (С ба Г 76), Көртландын Ариун сүмд Иосеф Смит Оливер Каудери хоёрт өгөгдсөн үзэгдлүүд (С ба Г 110), нас барагсдын гэтэлгэлийн талаарх Иосеф Ф.Смитийн үзэгдэл (С ба Г 138), Бурхан болон түүний бүтээлтийн талаарх Мосегийн үзэгдэл (Мосе 1), Бурханы тухай Енохын үзэгдлүүд (Мосе 6–7), Иосеф Смитийн анхны үзэгдэл (ИС—Т 1).

Үзэгдэл үгүй бол хүмүүс мөхнө, **Сур. үгс** 29:18. Залуу хүн үзэгдэл үзэх болно, **Иоел** 2:28 (Үйлс 2:17). Үзэгдлээр тэрээр надад мэдлэгийг өгсөн юм, **2 Ниф.** 4:23. Тэрээр Бурханы дэргэдээс илгээсэн элч байв, **ИС—Т** 1:33. Бид бошиглол, илчлэлт, үзэгдлүүдэд итгэдэг, **ИТ** 1:7.

ҮЗЭН ЯДАЛТ, ҮЗЭН ЯДАХ.

Дайсагнал; Өс хонзон; Хайрыг
мөн үз

Үзэн ядах гэдэг нь хэн нэгэнд буюу ямар нэг юманд туйлын дургүй байх явдал юм.

Бурхан би, намайг үзэн ядагчдын хүүхдийн дээр эцгүүдийнх нь нүглийн шийтгэлийг буулгадаг, **Ег.** 20:5. Эзэн эдгээр зургаан зүйлийг үзэн яддаг, **Сур.** үгс 6:16. Мунхаг хүн эхийгээ басамжилдаг, **Сур.** үгс 15:20. Тэр хүмүүсээр үзэн ядагдаж, татгалзагдав, **Иса.** 53:3. Өөрийг чинь үзэн ядагчдад сайныг үйлд, **Мат.** 5:44. Тэр нэгийг нь үзэн ядаж нөгөөг нь хайрлах болно; эсвээс нэгнээс нь зуурч, нөгөөг нь басамжилна, **Мат.** 6:24. Миний нэрнээс болж хүмүүс та нарыг үзэн ядна, **Мат.** 10:22. Хилэнцэтийг үйлдэгч болгон гэрлийг үзэн ядаг, **Иохан** 3:20. Хэн ч чамайг залуу хүн хэмээн дорд бүү үзэг, **1 Тим.** 4:12. Тэд баян учраас ядууг басамжилдаг, **2 Ниф.** 9:30. Бурханы илчлэлтүүдийг бүү басамжил, **Иаков** 4:8. Тэд бидний эсрэг мөнхийн үзэн ядалтын агуулдаг байв, **Иаков** 7:24. Хүмүүн Бурханы зөвлөгөөг үл ойшоон, мөн түүний үгсийг үл хэрэгсдэг, **С ба Г** 3:7. Би үзэгдэл харсан хэмээн хэлснийхээ төлөө үзэн ядагдаж мөн мөрдөн хавчигдаж байлаа, **ИС—Т** 1:25.

ҮЙЛЧЛЭЛ. Хайр; Халамжийг

мөн үз

Бурханы хийгээд бусдын ашиг тусын төлөө тавих халамж болон хийх ажил. Бид бусдад үйлчилснээр бас Бурханд үйлчилдэг.

Хэнд үйлчлэх вэ гэдгээ өнөөдөр өөрсдөдөө сонго, **Иош.** 24:15. Тэдний хамгийн дордод нь тийнхүү хандсан бол надад хийсэн хэрэг, **Мат.** 25:35–45. Өөрсдийн биеэ Бурханд өөрсдийн биеэ чиний тааламжит үйлчлэл болох амьд золиос болгон өргө, **Ром** 12:1. Хайраар бие биендээ үйлчил, **Гал.** 5:13. Чиний өдрүүд

Бурханыхаа үйлчлэлд зориулагдах, **2 Ниф.** 2:3. Та нар бусдадаа үйлчилж байх үед та нар зөвхөн өөрсдийн Бурханд үйлчилж байна, **Моз.** 2:17. Амлалтын нутгийг эзэмших хэн боловч Бурханд үйлчлэх ёстой, эсвээс аричгдах болно, **Ифег** 2:8–12. Бурханы үйлчлэлд дуудагдсан тэрээр бүх зүрх сэтгэлээрээ үйлчлэх ёстой, **С ба Г** 4:2. Хүн төрөлхтөн түүнийг хайрлаж мөн үйлчлэх ёстой хэмээх зарлигийг Их Эзэн өгсөн буюу, **С ба Г** 20:18–19. Есүс Христийн нэрээр чи Бурханд үйлчлэх ёстой, **С ба Г** 59:5. Их Эзэн бибээр, надад үйлчилдэг тэднийг хүндэтгэхдээ таатай байна, **С ба Г** 76:5. Бурханыг бишрэн шүт, учир нь зөвхөн түүнд чи үйлчлэх ёстой, **Мосе** 1:15.

ҮНДСЭН ХУУЛЬ. Засгийн газар;

Хуулийг мөн үз

Сургаал ба Гэрээнд “Үндсэн Хууль” гэж Сайн мэдээний сэргээлтийн замыг бэлтгэхийн тулд бурханлигаар өдөөгдсөн Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн Хуулийг хэлдэг.

Үндсэн хууль дэмжигдэв, **С ба Г** 98:5–6. Үндсэн Хуулийг бий болгоход Их Эзэн нөлөөлсөн билээ, **С ба Г** 101:77, 80.

ҮНЭН. Гэрэл, Христийн гэрэл;

Оюун билиг, Оюун билгүүд;

Мэдлэгийг мөн үз

Байгаа, байсан, мөн байх зүйлүүдийн тухай мэдлэг (**С ба Г** 93:24). Үнэн гэдэг нь тэрчлэн гэрэл хийгээд тэнгэрээс ирдэг илчлэлт мөн.

Үнэн газраас оргилох болно, **Дуул.** 85:11 (**Мосе** 7:62). Чи үнэнийг мэдэж, мөн үнэн чамайг чөлөөлөх болно, **Иохан** 8:32. Бибээр зам, үнэн, амьдрал билээ, **Иохан** 14:6. Хэрэв бид нүгэлгүй гэж хэлбэл бидний дотор үнэн алга, **1 Иохан** 1:8. Гэмтэнд үнэн хагуу санагдах бөлгөө, **1 Ниф.** 16:2. Зөв шударга хүн үнэнд дуртай, **2 Ниф.** 9:40. Сүнс үнэнийг ярьдаг бөгөөд худал хэлэх нь үгүй, **Иаков** 4:13. Та бол үнэний Бурхан,

худал хэлж чадахгүй, **Ифер** 3:12. Ариун Сүнсний хүчээр та бүх зүйлийн үнэнийг мэдэж болно, **Моро** 10:5. Үнэн үүрд мөн мөнхөд үлддэг, **С ба Г** 1:39. Та үнэний Сүнсээр гэгээрүүлэгдсэн билээ, **С ба Г** 6:15. Мормоны Ном үнэнийг мөн Бурханы үгийг агуулдаг, **С ба Г** 19:26. Тайтгаруулагч нь үнэнийг заахаар илгээгдсэн, **С ба Г** 50:14. Үгийг үнэний Сүнсээр хүлээн авдаг тэрээр үүнийг үнэний Сүнсээр номлогдсоны дагуу хүлээн авдаг, **С ба Г** 50:17–22. Миний өгсөн илчлэлтүүдийн дагуу үнэнийг тунхагла, **С ба Г** 75:3–4. Аливаа үнэн зүйл нь гэрэл болой, **С ба Г** 84:45. Христийн гэрэл бол үнэний гэрэл болой, **С ба Г** 88:6–7, 40. Миний Сүнс бол үнэн, **С ба Г** 88:66. Оюун билиг буюу үнэний гэрэл нь бүтээгдээгүй байсан, **С ба Г** 93:29. Бурханы алдар суу бол оюун билиг, буюу гэрэл ба үнэн, **С ба Г** 93:36. Хүүхдүүдээ гэрэл ба үнэнд авчрахыг би та нарт зарлигласан билээ, **С ба Г** 93:40. Миний Төрсөн Ганц бол бүрэн ач ивээл хийгээд үнэн болой, **Моце** 1:6.

ҮНЭН СҮМИЙН ТЭМДГҮҮД. Есүс Христийн Сүм; Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм; Тэмдгийг мөн үз

Сүмийн номлолууд хийгээд аждууд нь үүнийг Бурхан зөвшөөрсөн бөгөөд Их Эзэн өөрийн бүрэн адислалуудын тул хүүхдүүддээ бий болгосон арга хэрэгсэл мөн гэдгийг харуулдаг. Үнэн Сүмийн зарим тэмдгүүдийг дор дурдвал:

Бурхан тэргүүтний тухай үнэн зөв ойлголт: Бурхан хүнийг өөрийн дүр төрхөөр бүтээсэн, **Эхл.** 1:26–27. Их Эзэн Мосетой нүүр нүүрээрээ тулан ярив, **Ег.** 33:11. Мөнх амьдрал бол Бурхан Тэнгэрлэг Эцэг мөн Есүс Христийг мэдэх нь юм, **Иохан** 17:3. Эцэг болон Хүү мах болон ясан биетэй, **С ба Г** 130:22–23. Эцэг, Хүү хоёр Иосеф Смит дээр хүрч иржээ, **ИС—Т** 1:15–20. Бурхан Мөнхийн Эцэгт бид итгэдэг, **ИТ** 1:1.

Анхдагч зарчмууд ба ёслолууд: Ус болон Сүнснээс өөрөөр хүн төрөх ёсгүй **Иохан** 3:3–5. Та нар бүгдээрээ нанманчилж, Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ, **Үйлс** 2:38. Тэгээд тэд тэдэн дээр гараа тавихад мөн тэд Ариун Сүнснийг хүлээн авч байлаа, **Үйлс** 8:14–17. Есүс Христэд итгэх итгэлээр Бурханы хүүхдүүд болдог, **Гал.** 3:26–27. Наманчил та нар, мөн миний Төрсөн Хүүгийн нэрээр баптисм хүртэцгээ, **2 Ниф.** 31:11–21. Тэд бол баптисм хүртэж мөн гар тавилтаар Ариун Сүнснийг хүлээн авахад итгэгсэд байлаа, **С ба Г** 76:50–53. Баптисм хүртээж мөн Ариун Сүнсний бэлгийг өгөхөд зөв санваар хэрэгтэй, **ИС—Т** 1:70–72. Сайн мэдээний анхдагч зарчмууд болон ёслолууд дүрслэгдэв, **ИТ** 1:4.

Илчлэлт: Үзэгдэл үгүй бол хүмүүс мөхнө, **Сур.үг** 29:18. Их Эзэн өөрийн нууцуудыг бошиглогчиддоо илчилдэг, **Амос** 3:7. Сүм Илчлэлтийн хадан дээр баригддаг, **Мат.** 16:17–18 (**С ба Г** 33:13). Их Эзэн Илчлэлтээр ажиллахаа больсон хэмээн хэлэх түүнд халаг, **3 Ниф.** 29:6. Зөвхөн томилогдсон нэгнээр дамжин илчлэлтүүд болон зарлигууд ирдэг, **С ба Г** 43:2–7. Бурханы илчилсэн бүх зүйлд бид итгэдэг, **ИТ** 1:9.

Бошиглогчид: Сүм Төлөөлөгчид болон бошиглогчдын суурин дээр баригддаг, **Ефес** 2:19–20. Сүмд Төлөөлөгчид болон бошиглогчид гол үндэс нь юм, **Ефес** 4:11–16. Иосеф Смит үзмэрч, бошиглогч, мөн Төлөөлөгч байхаар дуудагдав, **С ба Г** 21:1–3. Бид бошиглогчдод итгэдэг, **ИТ** 1:6.

Эрх мэдэл: Есүс шавь нартаа хүч болон эрх мэдлийг өгсөн, **Лук** 9:1–2 (**Иохан** 15:16). Хиламаны хүү Нифай Бурханы агуу эрх мэдэлтэй байв, **Хил.** 11:18 (3 **Ниф.** 7:17). Бошиглогч нь Сүмд зарлигуудыг хүлээн авах ёстой, **С ба Г** 21:4–5. Эрх мэдэл бүхий нэгнээр томилогдохоос бусдаар хэн ч сайн мэдээг номлож мөн Сүмийг барьж чадахгүй, **С ба Г** 42:11. Ахлагч нар сайн мэдээг

номлож, эрх мэдлээр үйлдэх ёстой, **С ба Г** 68:8. Бурханы тул гүйцэтгэх буюу номлох хэн ч байсан, Бурханаас эрх мэдэлтэй тэднээр дуудагдах ёстой, **ИТ** 1:5.

Хойшид ирэх нэмэлт судрууд: Иудагийн саваа Иосефын саваатай нийлэх болно, **Езек.** 37:15–20. Хожмын үеийн судар ирэх нь угтан хэлэгдэв, **1 Ниф.** 13:38–41. Бурхан олон агуу бөгөөд чухал зүйлийг илчлэх болно гэдэгт бид итгэдэг, **ИТ** 1:9.

Сүмийн зохион байгуулалт: Сүм Төлөөлөгчид болон бошиглогчдын суурин дээр баригддаг, **Ефес** 2:19–20. Сүмд Төлөөлөгчид болон бошиглогчид гол үндэс нь юм, **Ефес** 4:11–16. Христ бол Сүмийн тэргүүн болой, **Ефес** 5:23. Христийн Сүм түүний нэрээр нэрлэгдэх ёстой, **3 Ниф.** 27:8. Анхны Сүмд байсан тэрхүү зохион байгуулалтад бид итгэдэг, **ИТ** 1:6.

Номлолын ажил: Иймээс явж, бүх үндэстнүүдэд номло, **Мат.** 28:19–20. Дал сайн мэдээг номлохоор дуудагдав, **Лук** 10:1. Аврал нь бүтээл бүрт тунхаглагдсан байвал зохино хэмээх хүсэл тэдэнд байв, **Моз.** 28:3. Ахлагч нар хоёр хоёроороо урагш явж, миний сайн мэдээг номлох ёстой, **С ба Г** 42:6. Сайн мэдээ хүн бүхэнд номлогдох ёстой, **С ба Г** 58:64.

Сүнсний бэлгүүд: Тэд өөр хэлээр ярьж эхэлцгээв, **Үйлс** 2:4. Ахлагч нар өвчтөнийг эдгээх ёстой, **Иаков** 5:14. Бурханы бэлгүүдийг бүү үгүйсгэ, **Моро.** 10:8. Сүнсний бэлгүүд жагсаагдав, **С ба Г** 46:13–26 (1 Кор 12:1–11; Моро 10:9–18).

Ариун Сүмүүд: Би гэрээ байгуулж мөн өөрийн дуганыг тэдний дунд мөнхөд байлгах болно, **Езек.** 37:26–27. Их эзэн өөрийнхөө ариун сүмд гэнэт ирэх болно, **Малах.** 3:1. Нифай ариун сүм барив, **2 Ниф.** 5:16. Гэгээнтнүүд Их Эзэний өргөөг барихдаа алдаа гаргасан учир зэмлэгдэв, **С ба Г** 95 (С ба Г 88:119). Их Эзэний хүмүүс ариун ёслолуудыг гүйцэтгэхийн тулд үргэлж ариун

сүмийг барьдаг, **С ба Г** 124:37–44. Ариун сүмүүдийг барьж мөн ёслолуудыг гүйцэтгэх нь хожмын үеийн агуу ажлын нэг хэсэг юм, **С ба Г** 138: 53–54.

ҮРЧИЛЖ АВАХ. Абрахам—
Абрахамын үр удам; Бурханы охид хөвгүүд; Израил;
Христийн хүүхдүүдийг мөн үз

Судрууд хоёр төрлийн үрчлэлтийн тухай өгүүлдэг.

(1) Израилын удмын бус хүн Есүс Христэд итгэлтэй болж, наманчлан, усанд умбуулах баптисм хүртэж, мөн Ариун Сүнс хүлээн авснаар Абрахамын гэр бүлийн болон Израилын удмын гишүүн болдог, (2 Ниф. 31:17–18; С ба Г 84:73–74; Абр. 2:6, 11).

(2) Сайн мэдээний авралын ёслолуудыг хүлээн авсан хүн бүхэн түүний зарлигуудад үргэлжлүүлэн дуулгавартай байснаар Есүс Христийн хөвгүүд охид болдог (Ром 8:15–17; Гал. 3:24–29; 4:5–7; Моз. 5:7–8).

ҮҮРДИЙН АМЬДРАЛ. Мөнх амьдралыг үз

ҮҮРДИЙН ГЭРЭЭ. Гэрээ; Шинэ бөгөөд үүрдийн гэрээг үз

ҮҮРЭГ. Дуулгавартай байдал, Дуулгавартай, Дуулгавартай дагахыг мөн үз

Судруудад, Их Эзэнээр буюу түүний үйлчлэгчдээр олонтаа өгөгддөг даалгавар, томилолт буюу үүрэг хариуцлага.

Түүний тушаалуудыг дага: учир нь энэ нь хүмүүний бүхэл үүрэг болой, **Ном. үгс** 12:13. Чамаас Их Эзэн зөв шударгаар үйлдэхээс өөр юуг ч шаардаагүй, **Мика** 6:8. Бид хүмүүнээс илүү Бурханыг дагах ёстой, **Үйлс** 5:29. Зовлон зүдгүүрүүдэд цохигдож өөрсдийн үүргийг сануулагдахаар бусниулагдав, **Моз.** 1:17. Ахлагч, санваартан, багш нар мөн диконы үүргүүд дүрслэгдэв, **С ба Г** 20:38–67. Санваартнууд гэр бүлийн

бүх үүргүүдэд оролцох ёстой, **С ба Г** 20:47, 51. Баптисм хийлгэсний дараах гишүүдийн үүргүүд дүрслэгдэв, **С ба Г** 20:68–69. Миний хүмүүс өөрсдийнхөө үүргүүдийн талаар илүү төгс мэдэж болохын тулд миний ахлагчид багахан хугацаанд хүлээх ёстой, **С ба Г** 105:10. Хүн бүр өөрсдийнхөө үүргийг мэдэж, **С ба Г** 107:99–100.

ҮХЛИЙН ШИЙТГЭЛ. Аллагыг

мөн үз

Гэмт хэрэг үйлдсэний төлөөх цаазаар авах шийтгэл, ялангуяа аллага үйлдсэний төлөөх шийтгэлтэй холбоотой.

Хэн хүний цусыг урсгана, түүний цусыг хүн урсгана, **Эхл.** 9:6 (ИСО, **Эхл.** 9:12–13). Алуурчин заавал үхэх ёстой, **Тоол.** 35:16. Санаатайгаар егүүтгэх алуурчин үхэх болно, **2 Ниф.** 9:35. Чи хуулийн дагуу үхэх ялтай, **Алма** 1:13–14. Аллага хийсэн нь үхлээр шийтгэгдэж байв, **Алма** 1:18. Хууль нь алсан түүний амийг шаарддаг, **Алма** 34:12. Алсан нь үхэх болно, **С ба Г** 42:19.

ҮХЭЛ, СҮНСНИЙ. Үхэл, Сүнсний үхлийг үз

ҮХЭШГҮЙ, ҮХЭШГҮЙ БАЙДАЛ.

Аврал; Амилуулалт; Есүс Христ; Мөнх бус, Мөнх бус байдал; Цагаатгал, Цагаатгахыг *мөн үз*

Амилуулагдсан байдалд, үхэл үзэлгүйгээр үүрд амьдрах нөхцөл.

Тэр амилсан, **Марк** 16:6. Христ дотор бүгд амьдруулагдах болно, **1 Кор.** 15:22. Энэ үхлийн бие нь үхэшгүйг өмсөх үед үхэл залгигдах болно, **1 Кор.** 15:53–54. Христ үхлийг устган, үхэшгүй байдлыг авчирсан, **2 Тим.** 1:10. Үхэшгүй байдал нь сүнсийг биетэй нь дахин сэргээх явдал болой, **2 Ниф.** 9:13. Биетэйгээ нэгдсэн сүнснүүд дахин хэзээ ч үхэшгүй болдог, **Алма** 11:45. Итгэлтнүүд үхэшгүй байдал ба мөнх амьдралын титмийг хүртэх болно, **С ба Г** 75:5. Дэлхий ариусгагдан, мөн үхэшгүй

болох болно, **С ба Г** 77:1 (С ба Г 130:9). Бурханы ажил хийгээд алдар суу нь хүмүүний үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрах явдал мөн, **Мосе** 1:39.

ФАРАО. Египет; Египетусыг *мөн үз*

Египетусын ууган хүү, Хамын охин (Абр. 1:25). Тэрчлэн, Египетийн хаадад өгсөн нэр (Абр. 1:27).

ФАРИСАЙЧУУД. Иудейчүүдийг

мөн үз

Шинэ Гэрээнд, иудейчүүдийн доторх шашны бүлэг, нэр нь тусгаарлагдсан буюу салсан гэсэн утгатай. Фарисайчууд Мосегийн хуулийг чанд сахидаг хэмээн өөрсдөөрөө бардамнан, харийнхантай холбоотой аливаа зүйлээс зайлсхийдэг байв. Тэд үхлийн дараах амьдрал, билуулалт хийгээд тэнгэр элчүүд болон сүнснүүд байдагт итгэдэг байлаа. Аман хууль хийгээд ёс заншил нь бичигдсэн хуулиудын нэгэн адил чухал ач холбогдолтой гэдэгт тэд итгэдэг байжээ. Тэдний сургаалууд дүрмүүдийг сахихад шашныг сулруулан, сүнсний бардамналыг хөхүүлэн дэмждэг байв. Тэд олон иудей хүмүүсийг Христ хийгээд түүний сайн мэдээнд эргэлзэхэд хүргэжээ. Фарисайчууд хийгээд тэдний ажлуудыг Их Эзэн Матай 23; Марк 7:1–23; мөн Лук 11:37–44-т буруушаасан байдаг.

ФЕЙЕТТЕ, НЬЮ-ЙОРК (АНУ)

Ахмад Петр Витмерийн эзэмшдэг байсан фермийн газар. Энд Бошиглогч Бага Иосеф Смитэд олон илчлэлт өгөгджээ. 1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд энд Сүм зохион байгуулагдаж, түүнчлэн Их Эзэний дуу хоолой сонсогдсон билээ (С ба Г 128:20).

ФЕЛПС, ВИЛЛЯМ В.

1830 онд Сүм сэргээгдсэний дараах анхны нэг гишүүн ба удирдагч. Их Эзэн Виллям Фелпсийг Сүмийн хэвлэгч байхаар дууджээ (С ба Г 57:11; 58:40; 70:1).

ФИЛЕМОН. Паулыг *мөн үз*

Шинэ гэрээнд гардаг Христэд итгэгч хүн, Онесим хэмээх зарцтай байжээ, тэр зарц зугтаж мөн Паултай нэгдэв, Паул зарцаа уучлахыг хүссэн захидлын хамт Онесимыг Филемонд гэдрэг буцаажээ.

ФИЛЕМОН, ТҮҮНД БИЧСЭН

ЗАХИДАЛ. Паул; Паулын захидлуудыг *мөн үз*

Паулын захидлуудаас авсан, Шинэ Гэрээн дэх нэг ном. Паулын захидал бол өөрийн эзэн Филемоныг дээрэмдээд Ром уруу зугтсан зарц Онесимын тухай хувийн захидал юм. Колосайчуудад бичсэн Паулын захидлыг хүргэсэн Тикисийн хамт Паул түүнийг Колосай дахь эзэнд нь буцаан явуулжээ. Онесимыг уучилж, Христэд итгэгч нөхрийн хувиар түүнийг буцаан авахыг Паул хүсчээ. Паул энэхүү захидлыг Ромд эхний удаад шоронд байхдаа бичжээ.

ФИЛИП

Шинэ Гэрээнд, Бетсайдын Филип нь Аврагчийн анхны Арванхоёр Төлөөлөгчийн нэг байв (Матай 10:2–4; Иохан 1:43–45).

Өөр нэг Филип нь Арванхоёр Төлөөлөгчид туслахаар сонгогдсон долоогийн нэг байв (Үйлс 6:2–6). Тэрээр Самарид, мөн түүнчлэн Этиопын тайганд номлов (Үйлс 8).

ФИЛИППЧҮҮД, ТЭДЭНД

БИЧСЭН ЗАХИДАЛ. Паул; Паулын захидлуудыг *мөн үз*

Паул Ромд анх удаа шоронд байхдаа Филиппой дахь Гэгээнтнүүдэд бичсэн захидал. Эдүгээ энэ нь Шинэ Гэрээн дэх Филиппойн ном юм.

Бүлэг 1 нь мэндчилгээ болон эв нэгдэл, даруу байдал хийгээд цөрөлтгүй чанарын талаарх түүний зааврыг агуулдаг. Бүлэг 2 нь бүгдээрээ Христэд өвдөг сөхөрч мөн хүн болгон өөрийн авралыг олохын төлөө ажиллах ёстойг онцлон тэмдэглэжээ. Бүлэг 3-т тэрбээр бүх

зүйлээ Христийн төлөө золиосолсноо тайлбарласан байдаг. Бүлэг 4-т Паул, тусалсных нь төлөө Филиппойн Гэгээнтнүүдэд талархал илэрхийлжээ.

ФИЛИСТЧҮҮД

Хуучин Гэрээнд, Кафтороос гарал үүсэлтэй (Амос 9:7) овог бөгөөд Абрахамын өдрүүдээс өмнө Иопшагаас Египетийн цөл хүртэлх Газрын Дундад Тэнгисийн эрэг дээрх баялаг үржил шимт нам дор газрыг эзэгнэдэг байжээ (Эхл. 21:32). Филистчүүд болон израилчуудын хооронд олон жилийн турш цэргийн тэмцэл болдог байв. Эцэстээ Филистины газар нутгийн нэр болох Палестин нь бүх Ариун Газрын танил нэр болжээ.

Израил дөчин жилийн турш филистчүүдийн боолчлолд байв, **Шүүгч. 13:1.** Самсон филистчүүдтэй тулалдав, **Шүүгч. 13–16.** Голиат бол Гатын филист хүн байв, **1 Сам. 17.** Давид филистчүүдийг бут ниргэв, **1 Сам. 19:8**

ХААД. Шастирыг *мөн үз*

Хуучин Гэрээн дэх хоёр ном. Эдгээр номнууд Давид Хааны (мээ 1015 оны орчим) дөрөв дэх хүү Адониагийн бослогоос эхлэн Иудаг бүрэн эзлэн боолчлох хүртэл (мээ 586 оны орчим) Израилын түүхийг өгүүлдэг. Эдгээр нь умард хаант улсын (Израилын арван овог) бүхэл түүхийг салан тусгаарласнаас эхлээд ассиричууд тэднийг умардын орнуудад боолчлолд аваачсаныг хүртэл хамардаг.

Хаадын Дээд: Бүлэг 1 нь Давид Хааны амьдралын сүүлчийн өдрүүдийг дүрсэлдэг. Бүлэг 2–11 нь Соломоны амьдралыг өгүүлдэг. Бүлэг 12–16 нь Соломоныг шууд залгамжлагчид, Рехобоам, Иеробоам нарын тухай өгүүлдэг. Иеробоам Израилыг хуваагдахад хүргэжээ. Түүнчлэн бусад хаад ч дурдагддаг. Бүлэг 17–21 нь Израилын хаан Ахавт сануулах үе дэх Елиагийн тохинууллын хэсгүүд

дийг өгүүлдэг. Бүлэг 22 нь Ахаб, Иудейн хаан Иехошафат хоёр хүчээ нэгтгэн Сирийн эсрэг дайтсан тухай өгүүлдэг. Бошиглогч Мика хаадын эсрэг бошиглож байв.

Хаадын Дэд: Бүлэг 1–2:11 нь Елиагийн амьдрал, түүний дотор галан тэргээр Елиа тэнгэрт дээшлэн одсон тухай өгүүлдэг. Бүлэг 2–9 Елишагийн итгэл хийгээд агуу хүчний тохинууллын тухай өгүүлдэг. Бүлэг 10 нь Хаан Иехугийн тухай мөн тэрээр Ахабын ордон болон Баалын санваартнуудыг хэрхэн устгасан тухай өгүүлдэг. Бүлэг 11–13 нь Иехоашийн зөв шударга хаанчлал хийгээд Елишагийн нас нөхсөн тухай өгүүлдэг. Бүлэг 14–17 нь Израил болон Иудад их төлөв ёс бусаар хаанчилж, асан олон өөр хаадын тухай өгүүлнэ. Бүлэг 15-д Израилын арван овгийг Ассири боолчлолд аваачсан тухай гардаг. Бүлэг 18–20 нь Иудейн хаан Хезекиагийн зөв шударга амьдрал, түүнчлэн бошиглогч Исаиагийн тухай өгүүлдэг. Бүлэг 21–23-нь Манассе болон Иосиа хаадын тухай гардаг. Ам дамжсан яриагаар Исаиагийн алагдсаны төлөө хариуцлагыг Манассе хүлээх ёстой ажээ. Иосиа бол иудейчүүдийн дунд хуулийг үндэслэн бий болгосон зөв шударга хаан юм. Бүлэг 24–25 нь Вавилоны боолчлолын тухай өгүүлдэг.

ХААНЫГ ХҮСЭГЧ ХҮМҮҮС

Мормоны Номонд, нифайчуудын засаглалыг түлхэн унагаахыг хүсдэг байсан бүлэг хүмүүс (Алма 51:1–8).

ХАБАККУК

Иехоиахины хаанчлалын үед хүмүүс нүгэлтэй болж болох тухай өгүүлсэн, Хуучин Гэрээний иудей бошиглогч (мэв 600 оны орчим).

Хабаккукийн ном: Бүлэг 1 нь Иеремиа 12 болон С ба Г 121-д байдагтай адил, Их Эзэн болон түүний бошиглогчийн хоорондох яриа юм. Ёс бусчууд цэцэглэн хөгжиж байгаа мэт

санагдаж байсанд Хабаккук зовж байжээ. Бүлэг 2-т Их Эзэн, тэвчээртэй байхыг, шударга хүмүүс итгэлээр амьдарч сурах ёстойг Хабаккукт зөвлөжээ. Бүлэг 3 нь Бурханы шударга ёсонд талархсан Хабаккукийн залбирлыг өгүүлдэг.

ХАГГАЙ

Ойролцоогоор мэв 520 оны орчимд иудей хүмүүс Вавилон дахь цөллөгөөсөө (Езра 5:1; 6:14) эргэж ирсний дараахан Иерусалимд бошиглож байсан Хуучин Гэрээний бошиглогч. Тэрээр Иерусалимд Их Эзэний ариун сүмийг дахин барих тухай ярьж мөн энэ нь дуусаагүй байсны учир хүмүүсийг зэмлэжээ. Тэрээр түүнчлэн мянганы ариун сүм хийгээд Аврагчийн хаанчлалын тухай бичсэн байдаг.

Хаггайн ном: Бүлэг 1-д ариун сүм баригдаж дуусаагүй байхад хүмүүс өөрсдийнхөө дууссан байшингуудад амьдарч байсныг Их Эзэн шүүмжилжээ. Бүлэг 2 нь Их Эзэн өөрийн ариун сүмд амар амгаланг авчрах болно хэмээх Хаггайн бошиглолыг өгүүлдэг.

ХАГОТ

Мормоны Номонд гардаг, хөлөг онгоц баригч нифай хүн (Алма 63:5–7).

ХАД. Есүс Христ; Илчлэлт; Сайн Мэдээг мөн үз

Бат бөх суурь хийгээд дэмжлэг болох Есүс Христ болон түүний Сайн Мэдээтэй жишин харьцуулжээ (С ба Г 11:24; 33:12–13). *Хад* нь түүнчлэн өөрийн сайн мэдээг хүмүүнд мэдүүлдэг Бурханы илчлэлтэд хамаардаг (Мат. 16:15–18).

Тэр бол хад, түүний ажил нь төгс, **Дэд хууль** 32:4. ЭЗЭН бол миний хад, түүнд би итгэнэ, **2 Сам.** 22:2–3. Хүний гар хүрэлгүйгээр цавчигдсан чулуу, **Дан.** 2:34–35. Энэ нь хадан дээр суурилагдсан байв, **Мат.** 7:25 (3 Ниф. 14:25). Есүс Христ бол

гологдсон чулуу билээ, **Үйлс** 4:10–11. Тэр хад бол Христ байв, **1 Кор.** 10:1–4 (Ег. 17:6). Хадан дээр баригддаг тэрээр үнэнийг хүлээн авдаг, **2 Ниф.** 28:28. Иудейчүүд дээр нь барьж болох тэр чулуунаас (Христ) татгалзах болно, **Иаков** 4:15–17. Энэ бол дээр нь бидний сууриа тавих ёстой Гэтэлгэгчийн маань хад билээ, **Хил.** 5:12. Христийн номлол дээр барьдаг, түүний хадан дээр барьдаг хэн боловч үер болоход унахгүй, **3 Ниф.** 11:39–40 (Мат. 7:24–27; 3 Ниф. 18:12–13). Мэргэн хүн байшингаа хадан дээр барьжээ, **3 Ниф.** 14:24. Хэрэв та нар миний хадан дээр баригдах аваас дэлхий хийгээд там дийлэх нь үгүй, **С ба Г** 6:34. Энэ хадан дээр барьдаг хүн хэзээ ч унахгүй, **С ба Г** 50:44. Бибээр Мессиа, Сионы Хаан, Тэнгэрийн Хад болой, **Мосе** 7:53.

ХАЙД, ООРСОН

Энэ эрин үед дуудагдсан анхны Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн (С ба Г 68:1–3; 75:13; 102:3; 124:128–129). Тэрээр сүмд олон ажил үүрэг гүйцэтгэсний дотор иудей хүмүүс эргэж ирэхийн тулд Ариун нутгийг 1841 онд онцгойлон адислажээ.

ХАЙР. Дайсагнал; Өрөвч сэтгэл;
Энэрлийг мөн үз

Гүнзгийгээр хайрлан энэрэх. Бурханыг хайрлах хайр нь хайрлан энэрэх, хүндэтгэх, бишрэх, уян зөөлөн сэтгэл, нигүүлсэл, уучлал, өрөвч сэтгэл, ач ивээл, үйлчлэл, талархал, нинжин сэтгэлийг өөртөө багтаадаг. Өөрийн хүүхдүүдийг хайрлах Бурханы хайрын хамгийн агуу үлгэр жишээ нь Есүс Христийн хязгааргүй цагаатгалд илрэлээ олсон билээ.

Хөршөө өөрийн адил хайрла, **Лев.** 19:18 (Мат. 5:43–44; Мат. 22:37–40; Ром 13:9; Гал. 5:14; Иаков 2:8; Моз. 23:15; С ба Г 59:6). Чи ЭЗЭН Бурханаа бүх зүрх сэтгэлээрээ хайрлах ёстой, **Дэд хууль** 6:5 (Моро. 10:32;

С ба Г 59:5). ЭЗЭН Бурхан чинь та нарыг бүх зүрх, бүх сэтгэлээрээ ЭЗЭН Бурхандаа хайртай эсэхийг чинь шалган үзэж байгаа юм, **Дэд хууль** 13:3. ЭЗЭН хайрладаг хүнээ зэмлэн залруулдаг, **Сур. үгс** 3:12. Анд найзууд ямар ч үед бие биенээ хайрладаг, **Сур. үгс** 17:17. Бурхан дэлхийг үнэхээр хайрласан учир цорын ганц Хүүгээ өгсөн, **Иохан** 3:16 (С ба Г 138:3). Би та нарыг хайрласны адил бие биенээ хайрла, **Иохан** 13:34 (Иохан 15:12, 17; Мосе 7:33). Хэрэв та нар намайг хайрладаг бол, зарлигуудыг минь сахигтун, **Иохан** 14:15 (С ба Г 42:29). Нөхдийнхөө төлөө амиа зориулахаас өөр агуу хайр байхгүй, **Иохан** 15:13. Петр, чи намайг тэднээс илүү хайрладаг уу? Миний хонинуудыг тэжээ, **Иохан** 21:15–17. Христ дэх Бурханы хайраас биднийг юу ч салгахгүй, **Ром** 8:35–39. Нүдэнд үзэгдээгүй юмсыг Бурхан өөрийг нь хайрладаг хүмүүст бэлджээ, **1 Кор.** 2:9. Хайраар бие биендээ үйлчил, **Гал.** 5:13. Нөхрүүдээ, эхнэрүүдээ хайрла, **Ефес** 5:25 (Кол. 3:19). Дэлхийг бүү хайрла, **1 Иохан** 2:15. Бурхан бол хайр мөн, **1 Иохан** 4:8. Тэр эхлээд биднийг хайрласан учраас бид түүнийг хайрладаг, **1 Иохан** 4:19. Хүмүүнийг хайрлах нинжин сэтгэлийнхээ улмаас Христ зовсон билээ, **1 Ниф.** 19:9. Бурханыг болон бүх хүмүүнийг хайрлах хайраар урагш тэмүүлэгтүн, **2 Ниф.** 31:20. Хайрлахыг, мөн бие биендээ үйлчлэхийг та нар хүүхдүүддээ заах болно, **Моз.** 4:15. Хэрэв та нар гэтэлгэгч хайрын дуу дуулмаар санагдаж байсан бол, та нар одоо тийн мэдэрч чадна уу? **Алма** 5:26. Ариун Сүнсээр удирдуулан, тэвчээртэй хүлцэнгүй хайраар дүүрэн байгтун, **Алма** 13:28. Чи хайраар дүүргэгдэж болохын тулд бүх хүслээ хязгаарла, **Алма** 38:12. Хүмүүсийн зүрх сэтгэлд орших Бурханы хайрын учир зөрчилдөөн байсангүй, **4 Ниф.** 1:15. Бурханы хайранд урьдаг юм болгон Бурханаас урамшуулагддаг билээ, **Моро.** 7:13–16. Энэрэл бол

Христийн цэвэр хайр мөн, **Моро.** 7:47. Төгс хайр айдсыг зайлуулдаг, **Моро.** 8:16 (1 Иохан 4:18). Хайр нь хүмүүнийг Бурханы ажилд тохирох болгодог, **С ба Г** 4:5 (С ба Г 12:8). Бурханыг хайрладаг мөн үйлчилдэг тэд бүгдэд ариусгал ирдэг, **С ба Г** 20:31. Хэрэв чи намайг хайрладаг бол надад үйлчилж мөн зарлигуудыг минь сахь, **С ба Г** 42:29 (Иохан 14:15). Засч залруулах буюу шүүмжлэх тэднийг хайрлах хайрыг нэмэгдүүлснээ харуул, **С ба Г** 121:43. Бурханаас илүүгээр Сатаныг хүмүүс хайрладаг байв, **Моце** 5:13, 18, 28.

ХАЛАМЖ. Мацаг, Мацаг барих;

Өглөг, Өглөг өгөх; Өргөл;
Үйлчлэл; Ядуусыг мөн үз

Хүмүүсийн сүнслэг хийгээд материаллаг хэрэгцээнд анхаарал тавих үйл явц буюу арга хэрэгсэл.

Өөрийнхөө газар нутаг дээрх үгээгүй, ядуу зүдүү ах дүүстээ чи гараа сунгаж бай, **Дэд хууль** 15:11. Ядуу хүнд өгөх тэр нь дутагдахгүй байх болно, **Сур. үгс** 28:27. Өлсгөлөн нэгэнтэй талхаа хуваан, орон гэргүй ядуусыг гэртээ оруулахын тулд мацаг барилгыг би сонгосон бус уу? **Иса.** 58:6–7. Намайг өлсөж байхад чи намайг хооллож, намайг харь хүн байтал оруулсан. Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь тэр ч байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг, **Мат.** 25:35–40. Эд хөрөнгөө ядуустай хуваа, **Моз.** 4:16–26. Тэд нэг нэгэндээ тэдний гачигдал хийгээд хүслийн дагуу биеийн мөн сүнсний аль алины нь тусламжийг өгч байв, **Моз.** 18:29. Бурханыг мэдээгүй тэдний тулд мацаг барих болон хүчирхэг залбиралд нэгдэхээр зарлигуулсан билээ, **Алма** 6:6. Аз жаргалынхаа төлөө, мөн түүнчлэн та нарын эргэн тойронд байгаа тэдний зол жаргалын төлөө залбир, **Алма** 34:27–28. Тэдний дунд бүх зүйл нь нийтийнх байв, **4 Ниф.** 1:3. Ядуусыг дурсан сана, **С ба Г** 42:30–31. Ядуус хийгээд гачигдагсад зочлон оч, **С ба Г** 44:6.

Ядуус хийгээд гачигдагсдыг бүх зүйл дээр дурсан сана, **С ба Г** 52:40. Хөрөнгөө ядууст өгдөггүй баян хүнд халаг, мөн сэтгэл ханадаггүй, залхуу болоод хөдөлмөрлөдөггүй ядууст халаг, **С ба Г** 56:16–17. Сионд ядуучууд тэдний дунд байгаагүй, **Моце** 7:18.

ХАМ. Ноа, Библийн патриархыг

мөн үз

Хуучин Гэрээнд, Ноагийн гурав дахь хүү (Эхл. 5:32; 6:10; Моце 8:12, 27).

Ноа түүний хөвгүүд, мөн тэдний гэр бүлийнхэн хөвөгч авдарт оров, **Эхл.** 7:13. Хамын хүү Канаан зүхэгдэв, **Эхл.** 9:18–25. Хамын засгийн газар патриархынх байсан бөгөөд санваарт бус, харин дэлхийн зүйлүүд хийгээд дэлхийн мэргэн ухаанд адислагдсан байлаа, **Абр.** 1:21–27. Хамын эхнэр Египетус Каины үр удам байв; тэдний охин Египетийн хөвгүүд Египетэд суурьшив, **Абр.** 1:23, 25 (Дуул. 105:23; 106:21–22).

ХАННА. Хуучин Гэрээний

бошиглогч Самуелыг *мөн үз*

Хуучин Гэрээний бошиглогч Самуелын эх. Их Эзэн залбирлынх нь хариуд Самуелыг Ханнад өгчээ (1 Сам. 1:11, 20–28). Ханна Самуелыг Их Эзэнд зориулжээ. Түүний талархлын дууг, Есүсийн эх Мариагийнхтай жишиж болно (1 Сам. 2:1–10; Лук 1:46–55).

ХАРААХ. Доромжлох, Доромжлол;

Тангараг; Хараалын бүдүүлэг
үг хэллэгийг үз

ХАРАХ, ХАРУУЛУУД.

Сэрэмжлүүлэг,
Сэрэмжлүүлэхийг *мөн үз*

Сонор сэрэмжтэй байх, хамгаалах. Бэлэн хийгээд бэлтгэгдсэн байж дуулгавартай дагадаг буюу хамгаалдаг хүн. Харуулууд бол бусдын сайн сайхны төлөө тусгай үүрэг хариуцлага хүлээхээр Их Эзэний төлөөлөгчдөөр дуудагддаг удирдагчид юм. Удирдагчдаар дуудагддаг хүмүүс

тэрчлэн дэлхийн үлдсэн хэсэгт харуулууд байх тусгай үүрэг хариуцлага хүлээдэг.

Би чамайг харуул болголоо, **Езек.** 3:17–21. Харуул нь өөрөөсөө бусдад сэрэмжлүүлгийн дуу хоолойг өргөдөг, **Езек.** 33:7–9. Тиймийн тул хар; учир нь чи Их Эзэнийхээ ирэх цагийг мэдэхгүй, **Мат.** 24:42–43 (**Мат.** 25:13; **Марк** 13:35–37; **С ба Г** 133:10–11). Уруу таталтанд орохгүйн тулд сэрэмжтэй байж мөн залбир, **Мат.** 26:41 (3 **Ниф.** 18:15, 18). Хэрэв чи өөрийгөө, өөрсдийн бодлуудаа, үгсээ, үйлүүдээ хянахгүй аваас та нар мөхөх болно, **Моз.** 4:30. Сүмийг тэргүүлж мөн хянахын тулд Алма санваартан болон ахлагчдыг томилсон билээ, **Алма** 6:1. Аврагчийг хараагүй хэн боловч таслагдах болно, **С ба Г** 45:44. Бишоп болон бусад нь Сүмийг хянахаар Бурханаас томилогддог, **С ба Г** 46:27. Их Эзэн цэцэрлэгт харуул тавьсан болой, **С ба Г** 101:44–58.

ХАРИЙНХАН

Судруудад хэрэглэгддэгээр, *Харийнхан* гэдэг нь нилээд хэдэн утгатай. Заримдаа энэ нь Израилын удмын биш хүмүүсийг хэлдэг байхад зарим үед Иудей удмын биш хүмүүсийг, мөн заримдаа хэдийгээр хүмүүсийн дунд Израил цусных байсан ч, сайн мэдээгүй үндэстнүүдийг хэлдэг. Хамгийн сүүлчийн утгаараа энэ үг ялангуяа Мормоны Ном болон Сургаал ба Гэрээнд хэрэглэгдсэн байдаг.

Израилчууд израил биш хүмүүстэй гэрлэдэггүй байв (харийнхан), **Дэд хууль** 7:1–3. Их Эзэн харийнханы гэрэл болон ирэх болно, **Иса.** 42:6. Петр харийнханд сайн мэдээг хүргэхээр зарлигдуулав, **Үйлс** 10:9–48. Бурхан харийнханд наманчлалыг түүнчлэн соёрхжээ, **Үйлс** 11:18. Иудейчүүд эсвэл харийнхан ялгаагүй бид нэг сүмд баптисм хүртдэг, **1 Кор.** 12:13. Харь үндэстнүүд Христ дотор сайн мэдээгээр дамжуулан хамтран өвлөгчид байх ёстой, **Ефес** 3:6. Мормоны Ном харийнханд

бичигдсэн буюу, **Мормоны Номны Эхний хуудас** (Морм. 3:17). Харийнханы дунд нэг хүн их усанд урагшлан одов, **1 Ниф.** 13:12. Харийнханаас бусад номнууд ирсэн юм, **1 Ниф.** 13:39. Сайн мэдээний бүрэн бдйдал харийнханд ирэх болно, **1 Ниф.** 15:13 (3 **Ниф.** 16:7; **С ба Г** 20:9). Энэ нутаг харийнханд эрх чөлөөний нутаг байх болно, **2 Ниф.** 10:11. Харийнхан зэрлэг чидуны модтой адилхан юм, **Иаков** 5. Сайн мэдээ харийнханы цаг үед урагш гарч ирэх болно, **С ба Г** 45:28 (**С ба Г** 19:27). Үг нь дэлхийн хязгааруудад эхлээд харийнханд, дараа нь иудейчүүдэд ирэх болно, **С ба Г** 90:8–10. Дал нь харийнханд тусгай гэрчүүд байх ёстой, **С ба Г** 107:25. Бүх үндэстнүүдийг, эхлээд харийнханыг, дараа нь иудейчүүдийг дуудахаар миний сүмийн ахлагчдыг урагш илгээгтүн, **С ба Г** 133:8.

ХАРИУЦЛАГА, ХАРИУЦЛАГАТАЙ, ХАРИУЦАХ. Сонголтыг үз

Бүх хүмүүс өөрсдийн эрмэлзэл, харьцаа, хүсэл хийгээд үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээдэг хэмээн Их Эзэн хэлсэн байдаг.

Хариуцлагын нас бол хүүхдүүд өөрсдийн үйлдлийн төлөө хариуцлага хүлээх, түүнчлэн нүгэл үйлдэх хийгээд наманчлах чадвартай байх нас юм.

Би хүн бүрийг өөрсдийнх нь замаар шүүх болно, **Езек.** 18:30. Бодлоггүй хэлсэн үг бүрийнхээ төлөө тэд хариуцлага хүлээх болно, **Мат.** 12:36. Ажил үүргийнхээ тайланг өг, **Лук** 16:2. Бид бүгдээрээ өөрсдийнхөө төлөө Бурханд хариуцлага хүлээнэ, **Ром.** 14:12. Үхэгсэд ажлуудынхаа дагуу шүүгдэх болно, **Илч.** 20:12. Бидний үгс, ажлууд, мөн бодлууд биднийг буруутгах болно, **Алма** 12:14. Сайныг ч, эсвээс мууг ч хийсэн бид өөрсдийнхөө шүүгч болой, **Алма** 41:7. Та нар өөрсдийнхөө төлөө үйлдэх нь зөвшөөрөгдсөн болой, **Хил.** 14:29–31. Хариуцлага хүлээх тэдэнд наманчлал мөн баптисмыг та

нар заах болно, **Моро**. 8:10. Хариуцлагын насанд ирсэн хүн бүхэн наманчилж мөн баптисм хүртэх ёстой, **С ба Г** 18:42. Бяцхан хүүхдүүдийг миний өмнө хариуцлага хүлээх болтол Сатан тэднийг уруу татаж чадахгүй, **С ба Г** 29: 46–47. Найман нас хүрээд хүүхдүүд баптисм хүртэх болно, **С ба Г** 68:27. Шүүлтийн өдөр бүх хүмүүс өөрсдийнхөө нүгэлд хариуцлагатай байх болно, **С ба Г** 101:78. Сайнаас мууг ялган мэдэх нь хүмүүнд өгөгдсөн; иймээс тэд өөрсдөдөө хариуцлагатай байх ёстой, **Мосе** 6:56. Хүмүүн өөрсдийн гэрийн төлөө шийтгэгдэнэ, **ИТ** 1:2.

ХАРИУЦЛАГЫН НАС. Бага насны хүүхдийн баптисм; Баптисм, Баптисм хүртэх — Баптисм бага насны хүүхдүүдэд шаардлагагүй; Хариуцлага, Хариуцлагатай, Хариуцах; Хүүхэд, Хүүхдүүдийг үз

ХАРРИС, МАРТИН. Мормоны Номны Гэрчүүдийг мөн үз

Мормоны Номны бурханлиг гарал хийгээд үнэний тухай гэрчилсэн Гурван гэрчийн нэг. Тэрээр Иосеф Смит хийгээд Сүмд санхүүгийн талаар тусалжээ. Хөрөнгөө зарж, мөнгөө Мормоны Номыг хэвлэхэд зориулахыг, (**С ба Г** 19:26–27, 34–35); Сүмд үлгэр дууриал байхыг (**С ба Г** 58:35); түүнчлэн тохинуулын зардлыг төлөхөд туслахыг Мартин Харрисаас Их Эзэн хүсчээ (**С ба Г** 104:26).

Мартин Харрис Сүмээс хөөгдсөн хэдий ч хожим нь бүрэн гишүүн болон эргэж иржээ. Тэнгэр элч Моронай болон Иосеф Смит Мормоны Номыг үүнээс орчуулсан алтан ялтсуудыг үзсэн тухайгаа Амьдралынхаа сүүлчид гэрчилжээ.

ХАРУУССАН ЗҮРХ. Даруу, Даруу байдал, Золиослол; Зүрх сэтгэл; Наманчлал, Наманчлах; Номхон дөлгөөн, Номхон дөлгөөн байдлыг мөн үз

Харууссан зүрхтэй байна гэдэг нь даруу, гэмшсэн, наманчилсан мөн

номхон дөлгөөн байх тэрчлэн энэ нь Бурханы хүсэлд хүлээн авагдахуйц байхыг хэлдэг.

Бибээр гэмшсэн мөн даруу сүнстэй хүнтэй хамт оршдог, **Иса**. 57:15. Христ өөрийгөө харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй хүмүүсийн төлөө өргөсөн, **2 Ниф**. 2:7. Харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийг Их Эзэнд тахил болгон өргө, **3 Ниф**. 9:20 (**С ба Г** 59:8). Зөвхөн харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй хүн баптисмд хүлээн авагддаг, **Моро**. 6:2. Есүс гэмшсэн зүрхний тулд нүглүүдийн ангижралын төлөө цовдлогдсон болой, **С ба Г** 21:9. Сүнс нь гэмшдэг тэд хүлээн зөвшөөрөгдсөн бөлгөө, **С ба Г** 52:15. Гэмшдэг тэдэнд Ариун Сүнс адислагдсан болой, **С ба Г** 55:3. Миний Сүнс даруу бөгөөд гэмшсэн нэгнийг гэгээрүүлэхийн тулд урагш илгээгддэг, **С ба Г** 136:33.

ХЕЗЕКИА

Хуучин гэрээн дэх иудей үндэстний зөв шударга хаан. Тэрээр Исаиаг Иудейд бошиглогч байх үед хорин есөн жил хаанчилжээ. (Хаад. дэд 18–20; Шаст. дэд 29–32; Иса. 36–39). Сүм болон төр аль алиныг нь шинэчлэхэд Исаиа түүнд тусалсан байна. Тэрээр хиймэл шүтээн бишрэхийг дарж, ариун сүмийн үйлчлэлийг дахин сэргээв. Хезекиагийн амьдрал залбирал ба итгэлээр дамжин арван таван жил уртасчээ. (Хаад. дэд 20:1–7) Түүний хаанчлалын эхэн үе цэцэглэл хөгжлийн үе байв, гэвч Ассирийн хааны эсрэг түүний бослого (Хаад. дэд 18:7) Ассирийн хоёр удаагийн довтолгоонд хүргэжээ; нэгдэх нь Исаиа 10:24–32-т, хоёр дахь нь Хаадын дэд 18:13–19:7-д байдаг. Хоёр дахь довтолгооноор Иерусалим Их Эзэний тэнгэр элчээр аврагджээ. (Хаад. дэд 19:35)

ХЕЙГАР. Абрахам; Абрахамын хүү; Ишмаэлыг мөн үз

Хуучин Гэрээнд, Сарагийн египет шивэгчин. Тэрээр Абрахамын эхнэр,

мөн Ишмаелын эх болжээ (Эхл. 16:1–16; 25:12; С ба Г 132:34, 65). Түүний хүүгээс агуу үндэстэн бий болно гэдгийг Их Эзэн Хейгарт амлажээ (Эхл. 21:9–21).

ХЕРОД

Есүс Христийн үетэй ойролцоо байсан Иудейн захирагчдын гэр бүл. Шинэ Гэрээний олон үйл явдалд тэд чухал хүмүүс байв. Хавсралт хүснэгтийг үз.

ХЕРОДИА

Шинэ Гэрээнд Херод Агрыйпын эгч. Тэр авга ах Херод Филиптэйгээ гэрлэж, охин Саломыг төрүүлжээ. Херодиа Салом хоёр Иохан Баптис-тыг цаазлуулахаар хуйвалджээ (Мат. 14:3–11).

ХЕРУБ


Тэнгэрлэг бүтээлүүдийг төлөөлүүлсэн дүрслэл бөгөөд тодорхой хэлбэр нь мэдэгдээгүй байна. Херуб нь ариун нандин газруудыг хамгаалахаар дуудагджээ.

Их Эзэн херубыг амьдралын модны замыг хамгаалуулахаар байрлуулжээ, **Эхл.** 3:24 (Алма 12:21–29; 42:2–3; Мосе 4:31). Херубыг төлөөлүүлсэн бэлэгдлийг өршөөлийн суудал дээр байрлуулжээ, **Ег.** 25:18, 22 (Хаад. дээд 6:23–28; Евр. 9:5). Езекилийн үзэгдэлд херубуудыг дурджээ, **Езек.** 10; 11:22.

ХИЙМЭЛ ШҮТЭЭН

Хиймэл шүтээнүүдийг шүтэх, ямар нэг юманд хэт их шимтэх буюу зориулах.

Чи надаас өөр бурхадтай байж болохгүй, **Ег.** 20:3 (Моз. 12:35; 13:12–13). Хэрэв чи бусад бурхдын араас дагах юм бол, чи зайлшгүй мөхөх болно, **Дэд хууль** 8:19. Зөрүүдлэх нь алдас болоод хиймэл шүтээн шүтэхтэй адил билээ, **1 Сам.** 15:23. Чи өөрийгөө надаас өөр нэгэнд нээн харуулсан ажгуу, **Иса.** 57:8. Чи алт болоод мөнгөний бурхдыг магтсан



билээ, **Дан.** 5:23. Та нар Бурхан хийгээд эд баялаг хоёуланд нь зэрэг үйлчилж чадахгүй, **Мат.** 6:24. Шунахайрал бол хиймэл шүтээн бишрэх явдал мөн, **Кол.** 35. Хүүхдүүд ээ, хиймэл шүтээнүүдээс өөрсдийгөө хол байлга, **1 Иохан** 5:21. Хиймэл шүтээн бишрэгч тэдэнд халаг, **2 Ниф.** 9:37. Нифайн хүмүүсийн хиймэл шүтээн нь тэдний дайнууд хийгээд сүйрлүүдийг өөрсөд дээр нь авчирчээ, **Алма** 50:21. Хүн болгон өөрийн дүр төрх бүхий бурхны араас даган алхаг, **С ба Г** 1:16. Хиймэл шүтээн байхгүй байхын тулд өөрсдийн гараар хөдөлмөрлөг, **С ба Г** 52:39. Абрахамын эцэг хиймэл шүтээн бишрэх явдлаар зайцуулагдсан байв, **Абр.** 1:27.

ХИЛАМАН, АЛМАГИЙН ХҮҮ.

Алма, Алмагийн хүү; Антай-Нифай-Лихайчууд; Хиламан, түүний хөвгүүдийг *мөн үз*

Мормоны Номонд, Алмагийн Хүү Алмагийн ууган хүү (Алма 31:7). Хиламан бошиглогч бөгөөд цэргийн жанжин байв.

Алма өөрийн хүмүүсийн цэдгүүд хийгээд жаредчуудын ялтсуудыг хүү Хиламандаа итгэмжлэн хүлээлгэж өгөв, **Алма** 37:1–2, 21. Алма Хиламанд хүмүүсийнхээ түүхийг үргэлжлүүлэн бичихийг зарлиглав, **Алма** 45–62. Хиламан Сүмийг дахин төвхнүүлэв, **Алма** 45:22–23. Аммоны хоёр мянган залуу дайчид Хиламаныг өөрсдийн удирдагч байхыг хүсэв, **Алма** 53:19, 22. Хиламан болон түүний Аммоны хөвгүүд леменчүүдийн эсрэг тулалдаж мөн итгэлээрээ хамгаалагдан амьд үлдэв, **Алма** 57:19–27.

ХИЛАМАН ТҮҮНИЙ ХӨВГҮҮД.

Антай-Нифай-Лихайчууд;
Хиламан, Алмагийн хүүг *мөн үз*

Мормоны Номонд, аммончууд хэмээгддэг байсан хөрвүүлэгдсэн леменчүүдийн хөвгүүд Хиламаны удирдлаган дор дайчид болжээ (Алма 53:16–22).

Хиламан тэднийг өөрийн хөвгүүд хэмээн нэрлэхээр зохистой гэж үздэг байжээ, **Алма** 56:10. Тэдний эхчүүд Их Эзэн тэднийг чөлөөлөх чадвартай гэдэгт эргэлзэхгүй байхыг тэдэнд зааж сургажээ, **Алма** 56:47. Тэд леменчүүдийг бут ниргэж, нэг нь ч алагдаагүй тийм итгэлээр хамгаалагдан амьд үлдсэн байв, **Алма** 56:52–54, 56; 57:26.

ХИЛАМАН, ХААН

БЕНЖАМИНЫ ХҮҮ.

БЕНЖАМИН, Мозаягийн эцгийн *мөн үз*

Мормоны Номонд, Хаан Бенжамин гурван хүүгийн нэг (Моз. 1:2–8).

ХИЛАМАН, ХИЛАМАНЫ ХҮҮ

Нифайн хүмүүст заадаг байсан, Мормоны Номын бошиглогч хийгээд цэдэг хөтлөгч. Тэрээр Бага Алмагийн ач хүү бөгөөд бүх бичил хэсгүүдийн дээгүүрх хүч өгөгдсөн Нифайн эцэг байв (Хил. 5–10). Хиламаны номыг хүү Нифайнхаа хамт Хиламан бичжээ.

Хиламаны Ном: Бүлэг 1–2 нь улс төрийн агуу хямралын үеийг дүрсэлдэг. Бүлэг 3–4 нь нифайчуудын их цэргийн ерөнхий ахмад Моронайха, Хиламан нар эцсийн эцэст түр хугацаанд энх тайвныг тогтоож чадсан тухай өгүүлдэг. Гэсэн хэдий ч, эдгээр сайн хүмүүсийн удирдлагыг үл хайхран, хүмүүс улам бүр ёс бус болсоор байв. Бүлэг 5–6-д Нифай, өөрийн өвөг эцэг Алмагийн адилаар, хүмүүст заахын тулд шүүгчийн суудлыг орхив. Хэсэг хугацаанд хүмүүс наманчлав. Гэвч, бүлэг 6–12-г нифай үндэстэн ёс бус болов. Сүүлчийн бүлгүүд 13–16 нь Аврагч төрөх болон түүний цовдлолт хийгээд эдгээр үйл явдлуудын дохио болох тэмдгүүдийн талаар угтан хэлсэн лемен хүн Самуел хэмээгдэх бошиглогчийн ер бусын шастирыг агуулдаг.

ХИЛЭГНЭЛ. Уурыг үз

ХИЛЭНЦТИЙГ ЯРИХ. Дэмий ярих; Зөрчилдөөн: Худал хэлэх; Цуурхлыг *мөн үз*

Буруу хортой, ёс бус зүйлүүдийг ярих. Сударт ийм яриа нь эмзэглэл төрүүлэх тусгай зорилго бүхий хүнд хамаатай байх нь олонтаа тохиолддог.

Хэлээ хорон муугаас сахин хамгаал, **Дуул.** 34:13, (1Петр 3:10). Бурханлиг бус хүн хорон мууг ухаж гаргадаг, **Сур. үгс** 16:27. Хүмүүс та нарын эсрэг зүсэн бүрийн хорон мууг ярихад та нар ерөөлтэй еэ, **Мат.** 5:11, (3 Ниф 12:11). Зүрхнээс хорон муу бодол гардаг, **Мат.** 145:19, (Марк 7:21). Чи удирдагчийн талаар хилэнцтийг ярих ёсгүй, **Үйлс** 23:5. Бүхий л хилэнцтийг ярих нь та нараас зайлуулагдаг, **Ефес** 4:31. Бие биенийхээ тухай хилэнцэтийг бүү ярь, **Иаков** 4:11. Хов жив хөөцөлдөхгүй, муугаар ярихгүй байхад анхаарагтун, **С ба Г** 20:54.

ХИМНАЙ. Мозая, Бенжамины хүү; Мозаягийн хөвгүүдийг *мөн үз*

Мормоны Номонд Хаан Мозаягийн хүү. Химнай ах нарынхаа хамт лемэнчүүдэд номлохоор явжээ (Моз. 27:8–11, 34–37; 28:1–9).

ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ

Ялангуяа Их Эзэнд үйлчилж мөн түүний үгийг дагахад гаргах байнгын, эрс шийдмэг хүчин чармайлт.

Намайг анхааралтай сонс, **Иса.** 55:2. Бурхан өөрийг нь хичээнгүйгээр хайгч тэдэнд шагнагч нь болдог, **Евр.** 11:6. Бүхий л хичээл зүтгэлээр итгэл дээрээ сайн давуу байдлыг нэм, **2 Петр** 1:5. Бурханы үгийг бүх хичээл зүтгэлээрээ заа, **Иаков** 1:19. Тэд судруудыг хичээнгүйлэн судалсан байв, **Алма** 17:2. Тэд бүхий л хичээнгүй байдлаараа зарлигуудыг дагахад бэлэн байв, **3 Ниф.** 6:14. Бүгдээрээ хичээнгүйлэн хөдөлмөргөдгөөе, **Моро.** 9:6. Сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориул, **С ба Г**

58:27. Залхуу бүү бай, харин бүх хүчээрээ хөдөлмөрлө, **С ба Г** 75:3. Мөнх амьдралын үгсэд хичээнгүйлэн анхаарал тавь, **С ба Г** 84:43. Хүн бүр өөрсдийнхөө үүргийг сурч, мөн бүх хичээл зүтгэлээр гүйцэтгэг, **С ба Г** 107:99.

ХИШИГ. Ариун Сүм, Их Эзэний өргөөг *мөн үз*

Ерөнхий утгаараа Бурханаас ирдэг хүч чадлын бэлэг. Сүмийн зохистой гишүүд өргөмжлөлийг хүртэхийн тулд тэдэнд шаардлагатай заавар хийгээд Ариун санваарын гэрээнүүдийг өгдөг ариун сүм дэх ёслолуудаар дамжуулан хүч чадлын бэлгийг хүлээн авч чадна. Хишиг нь авралын төлөвлөгөөний талаарх зааврыг багтаадаг.

Тэнд та нар тэнгэрийн хүчээр хишиг хүртээгдэх болно, **С ба Г** 38:32, 38 (Лук 24:49; С ба Г 43:16). Тэнгэрийн хүчээр миний сонгосон тэдэнд хишиг хүртэхээр миний төлөвлөж буй өргөөг баригтун, **С ба Г** 95:8. Агуу хишиг хийгээд адислалыг би бэлтгэлээ, **С ба Г** 105:12, 18, 33. Миний үйлчлэгчдийн хүртсэн тэрхүү хишгийн учир олон нь баясан цэнгэх болно, **С ба Г** 110:9. Алдар суу, хүндэтгэл мөн хишиг миний ариун өргөөний ёслолоор томилогддог бөлгөө, **С ба Г** 124:39. Аароны нэгэн адил Эцэгээс дуудагддаг тэдэнд санваарын түлхүүрүүдээр хишиг хүртээгддэг, **С ба Г** 132:59.

ХОВ ЖИВ, ДЭМИЙ ЯРИА.

Хилэнцтийг ярих; Цуурхлыг *мөн үз*

Хувь хүний тухай баримт буюу мэдээллийг уг хүний зөвшөөрөлгүйгээр өөр хүнд ярих.

Бодлогогүй хэлсэн үг бүрийнхээ төлөө хүмүүс шүүлтийн өдөр тайлагнах болно, **Мат.** 12:36. Гэгээнтнүүд хов жив хөөцөлдөгчид, сул үг яригчид, мөн ярих ёсгүй юмсыг ярьдаг байхгүйн тулд сануулагдах ёстой, **1 Тим.** 5:11–14. Чи хөршийн-

хөө талаар хилэнцэтийг ярих ёсгүй, **С ба Г 42:27**. Бүхий л ярилцлагуудаараа ахан дүүсээ хүчирхэгжүүл, **С ба Г 108:7**.

ХОГИЙН УРГАМАЛ (ЗЭРЛЭГ ӨВС)

Үр тариатай төстэй өвс буюу хортой хогийн ургамал. Энэ нь бүрэн ургаж гүйцэтлээ үр тарианаас ялгардаггүй (Мат. 13, 24–30; С ба Г 86:1–7).

ХОЁР ДАХЬ БАЙДАЛ. Мөнх бус, Мөнх бус байдлыг үз

ХОЁР ДАХЬ ТАЙТГАРУУЛАГЧ. Тайтгаруулагчийг үз

ХОЁР ДАХЬ ҮХЭЛ. Сүнсний үхлийг үз

ХОНЬЧИН. Сайн Хоньчин; Есүс Христийг мөн үз

Бэлгэдлээр, Их Эзэний хүүхдүүдэд анхаарал халамж тавьдаг хүн.

Их Эзэн бол миний Хоньчин, **Дуул. 23:1**. Хоньчид хонин сүргээ тэжээх ёстой, **Езек. 34:2–3**.

ХООСОН, ХООСОН ЧАНАР. Бардамнал; Дэлхийн шинж байдлыг мөн үз

Худал хуурмаг буюу залилан мэхлэх явдал; бардамнал. *Хоосон, хоосон шинж* нь тэрчлэн хоосон буюу үнэ цэнэгүй гэсэн утгатай байж болдог.

Хуурмаг байдалд сэтгэлээ өргөөгүй хүн Их Эзэний ариун газарт зогсох болно, **Дуул. 24:3–4**. Залбирч байхдаа хоосон үг бүү давт, **Мат. 6:7**. Агуу хийгээд нүсэр барилга нь хоосон төсөөлөл хийгээд бардамнал болой, **1 Ниф. 12:18**. Та нар зүрх сэтгэлээ дэлхийн хоосон зүйлүүд дээр тавьсаар л байх уу? **Алма 5:53**. Энэ дэлхийн хоосон зүйлсийг бүү эрэлхийл, учир нь чи тэдгээрийг өөртэйгөө аваад явж чадахгүй, **Алма 39:14**. Хуурмаг зүйл болон итгэлгүй байдал нь Сүмийг ээмлэл дор авчирдаг, **С ба Г 84:54–55**. Биднийг хоосон санаархлаараа сайрха-

хыг хичээхэд тэнгэр өөрийгөө татан авдаг, **С ба Г 121:37**.

ХОРИГЛОГДСОН ЖИМС. Адам Ева хоёрын Уналт; Еденийг үз

ХОСАННА

“Биднийг аварна уу” гэсэн утгатай еврей үг бөгөөд магтаал болон даруухан залбиралд хэрэглэгддэг.

Израилыг амлагдсан нутаг өөд чөлөөлсөн Их Эзэний чөлөөлөлтийг тэмдэглэдэг байсан Асрын Баяраар хүмүүс Дууллын 18-ын үгсийг магтуу болгон дуулж, дал модны мөчрөөр далладаг байжээ. Иерусалимд орсон Их Эзэний ялгуусан оролтын үеэр цугласан олон Хосанна хэмээн хашгирч, Есүсийг дээр нь явахад зориулж дал модны мөчир дэвсэн, ийнхүү Есүс бол Израилыг эрт дээр үед чөлөөлсөн тэрхүү Их Эзэн мөн гэдгийг харуулдаг байв (**Дуул. 118:25–26; Мат. 21:9, 15; Марк 11:9–10; Иохан 12:13**). Эдгээр хүмүүс Есүсийг удаан хүлээсэн Мессиа мөн хэмээн үзэж байв. *Хосанна* хэмээх үг бүх үеийн туршид Мессиаг баяр ёслолын байдалтайгаар тэмдэглэх болсон байна (**1 Ниф. 11:6; 3 Ниф. 11:14–17**). Көртландын Ариун Сүмийг онцгойлон адислах үед хосанна хэмээн хашгирч байсан (**С ба Г 109:79**) бөгөөд мөн эдүгээ орчин үеийн ариун сүмүүдийн онцгойлон адислалтын хэсэг болжээ.

ХОСЕА

Хоёрдугаар Иеробоамын хаанчлалын сүүлчээр умарт Израилын хаант улсад бошиглож байсан Хуучин Гэрээний бошиглогч. Тэрээр Израилын нүглийн үр дүн болох үндэсний буурал доройтол, сүйрлийн үед амьдарч байв.

Хосеагийн ном: Номны үндсэн сэдэв бол өөрийн хүмүүсийг хайрлах Бурханы хайр юм. Түүний бүхий л шүүмжлэлүүд хайранд илэрч, түүнчлэн Израилын сэргэлт түүний хайранд байх болно гэдгийг харуулжээ (**Хосеа 2:19; 14:4**). Үүний эсрэгээр

Израил итгэл эвдэн, урван тэрсэлснийг Хосеа харуулдаг. Тиймээс Израилын эцсийн гэтэлгэлийг Бурхан хүсэн хүлээх боломжтой юм (Хосеа 11:12–14:9).

ХӨВГҮҮД, МОЗАЯГИЙН.

Мозаягийн хөвгүүдийг үз

ХӨВГҮҮД, ХИЛАМАНЫ.

Хиламаны хөвгүүдийг үз

ХӨВӨГЧ АВДАР. Библийн

патриарх; Ноагийн үеийн үер;

Солонгыг мөн үз

Хуучин Гэрээнд агуу их усны үерийн үеэр амьд амьтдыг хадгалан үлдэхийн тулд Ноагаар баригдсан хөлөг онгоц.

Чи хуш модоор хөвөгч авдар хий, **Эхл.** 6:14. Хөвөгч авдар Арарат ууланд тогтов, **Эхл** 8:4. Жаредчуудын хөлгүүд яг Ноагийн хөвөгч авдар адил нягт байв, **Иффер** 6:7.

ХӨВЧ ХӨНДӨХ ЁСЛОЛ.

Абрахамын гэрээг мөн үз

Хуучин Гэрээний эрин үеүдийн турш эрэгтэй израилчуудад зориулсан Абрахамын гэрээний тэмдэг (**Эхл.** 17:10–11, 23–27; **ИСО,** **Эхл.** 17:11). Хөвч хөндөх ёслолыг гүйцэтгэхдээ нялх эрэгтэй хүүхдийн болон насанд хүрсэн “эрэгтэй хүний бэлэг эрхтний хөвч арьсыг” хөнддөг байв. Үүнийг хүлээн авсан тэд энэхүү боломжид талархаж мөн гэрээний хариуцлагыг хүлээн зөвшөөрдөг байжээ. Гэрээний тэмдэг болох хөвч хөндөх ёслол Христийн үүрэг зорилгоор эцэс болжээ (**Моро.** 8:8; **С ба Г** 74:3–7).

ХӨГЖИМ. Дууллууд; Дуулахыг

мөн үз

Баяр хөөр, магтаал түүнчлэн шүтлэгийг илэрхийлэхийн тулд библийн эхэн үеэс эхлэн дуулагдаж буюу тоглогдож ирсэн аялгуу хийгээд айзамт хэмнэлүүд (**2 Сам.** 6:5). Энэ нь залбирлын нэг хэлбэр байж болно. Дууллуудыг энгийн аялгуу-

гаар хийгээд хөгжмийн зэмсгүүдээр ая хамтран дуулдаг байсан бололтой.

Аарон, Мосе нарын эгч Мириам хэнгэрэг авч мөн тэр болон эмэгтэйчүүд бүжиглэв, **Ег.** 15:20. Бүх Левийн дуучид цан, босоо ятга, ятга хөгжимтэй байлаа, мөн нэг зуун хорин санваартан бүрээ үлээж байв, **Шаст.** дэд. 5:12. Есүс болон Арванхоёр нь Сүүлчийн Зоогийн дараа магтуу дуулав, **Мат.** 26:30. Сүнслэг дуунууд, магтуу, дууллуудыг бие биендээ заан, бие биенээ сэнхрүүлэгтүн, **Кол.** 3:16. Та нар гэтэлгэх хайрын дууг дуулмаар санагдаж байна уу?, **Алма** 5:26. Зүрх сэтгэлийн дуунд Бурханы бодгаль баясдаг бөлгөө; тийм ээ, зөв шударгын дуу бол залбирал мөн, **С ба Г** 25:12. Их Эзэнийг дуугаар, хөгжмөөр, мөн бүжгээр магтагтун, **С ба Г** 136:28.

ХӨНГӨН ХУУМГАЙ ЯВДАЛ.

Хилэнцгийг ярихыг мөн үз

Ариун нандин зүйлүүдэд хөнгөмсгөөр хандах (**С ба Г** 84:54).

Гэгээнтнүүдэд залхаж бодол санаа мөн тэрчлэн илүүц чанга инээд байх ёсгүй, **С ба Г** 88:69. Өөрсдийнхөө бүхий л бардамнал хийгээд хөнгөн хуумгай явдлыг зогсоогтун, **С ба Г** 88:121.

ХӨӨХ. Урвалт; Эсэргүүцлийг

мөн үз

Хүнийг сүмээс хөөж, гишүүнчлэлийн бүх эрх хийгээд онцгой боломжуудыг нь хасах үйл явц. Зөвхөн Их Эзэний зарлигуудын эсрэг амьдрахаар сонголт хийсэн үед нь л Сүмийн эрх баригчид хүнийг сүмээс хөөдөг бөгөөд ийнхүү Сүмд цаашид гишүүн байх боломжгүй болдог.

Олны зүрх сэтгэл хатуурч, мөн тэдний нэрс арилгагдав, **Алма** 1:24, (**Алма** 6:3). Хэрэв тэр наманчлахгүй аваас, тэрбээр миний хүмүүсийн дунд тоологдохгүй, **3 Ниф.** 18:31, (**Моз.** 26). Эс наманчилдаг садар самууныг үйлдэгсэд зайлуулагдах болно, **С ба Г** 42:24. Нүгэл үйлддэг хийгээд эс наманчилдаг тэрээр

зайлуулагдах болно, **С ба Г** 42:28. Сүм дэх чухал бэрхшээлүүдийг шийдвэрлэх журмууд өгөгдсөн болой, **С ба Г** 102, (С ба Г 42:80–93). Бишоп нь Израилд шүүгч байхаар томилогддог, **С ба Г** 107:72. Шашны нийгэмлэгүүд гишүүдийнхээ зүй бус зан авирыг зохицуулах эрхтэй байдаг, **С ба Г** 134:10.

ХӨРВӨГЧ, ХӨРВҮҮЛЭГ.

Бурханаас төрөх, Дахин төрөх;
Шавийг *мөн үз*

Бурханы тааллыг хүлээн зөвшөөрч мөн дагахын тулд хүн итгэл, зүрх сэтгэл, болон амьдралаа өөрчлөх (Үйлс 3:19).

Хөрвүүлэг нь урьдын замаа орхиж, Христийн шавь болохын тулд өөрчлөгдөхөөр гаргасан зоримог шийдвэр юм. Наманчлал, нүглүүдийн ангижралын төлөөх баптисм, гар тавилтаар Ариун Сүнс хүлээн авах болон Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээ үргэлжлүүлэх нь хөрвүүлгийг төгс болгодог. Эгэл хүн ариусагдаж мөн цэвэр ариун шинэ хүн болон өөрчлөгдөж, Христ Есүс дотор дахин төрөх болно (2 Кор. 5:17; Моз. 3:19).

Хүмүүс өөрчлөгдөж бяцхан хүүхдүүдтэй адил болох ёстой, **Мат.** 18:3 (Моз. 3:19). Өөрчлөгдөх үедээ ах дүү нараа батжуул, **Лук** 22:32. Тэд түүний үгийг баяртайгаар хүлээн авч баптисм хүртэцгээв, **Үйлс** 2:37–41. Алдаатай замаас нь нүгэлтнүүдийг хөрвүүлж ав, **Иаков** 5:20. Инос хөрвүүлэгдэв, **Инос** 1:2–5. Бенжамин хааны үгс хүмүүст агуу өөрчлөлтийг авчирсан билээ, **Моз.** 5:2 (Алма 5:12–14). Бүх хүн төрөлхтөн дахин төрөх, тийм ээ, Бурханаас төрөх ёстой, **Моз.** 27:25. Алма болон Мозаягийн хүүхдүүд хөрвүүлэгдэв, **Моз.** 27:33–35. Лемонайн аав хөрвүүлэгдэв, **Алма** 22:15–18. Бурханы үг болон хүчээр тэд Их Эзэнд хөрвүүлэгдэв, **Алма** 53:10. Наманчлал нь зүрх сэтгэлийн өөрчлөлтийг авчирдаг, **Хил.** 15:7. Хөрвүүлэгдсэн болгон нь тэдэнд Бурханы Сүнс болон хүчээр зочлогд-

соныг үнэхээр харуулсан бөлгөө, **3 Ниф.** 7:21. Христэд итгэх тэдний итгэлийн учир тэдний хөрвүүлгийн үед тэд галаар мөн Ариун Сүнсээр баптисм хүртсэн бөлгөө, **3 Ниф.** 9:20. Тэд урагш явж мөн наманчлалыг номлох болно, мөн олон нь хөрвүүлэгдэх болно, **С ба Г** 44:3–4.

ХӨШИГ

Энэ үг судруудад (1) Сүм буюу асрын тусгаарлагдах хэсгүүдийг хуваагч, (2) Бурхан хүн хоёрыг хооронд нь тусгаарлах бэлэгдэл, (3) хүний нүүр буюу толгойгоо халхлах нимгэн хувцас, (4) мөнх бус амьдралын өмнөх хүний дурсамжийг хаахын тулд Бурханы өгсөн мартагнал гэсэн утгыг илэрхийлэхэд ашиглагддаг.

Хөшиг нь ариун газар ба ариунаас ариун газрыг хооронд нь зааглах болно, **Ег.** 26:33. Христийг цовдлогдох үед ариун сүмийн хөшиг дундуураа цуурчээ, **Мат.** 27:51 (Марк 15:38; Лук 23:45). Бид одоо толинд бүдэг бадаг хардаг ч, харин дараа нь нүүр нүүрээ харна, **1 Кор.** 13:12. Итгэлгүй байдлын харанхуй гивлүүр түүний оюунаас зайлуулагджээ, **Алма** 19:6. Жаредын ах гивлүүрийн доторхыг харахгүйгээр хадгалагдах аргагүй байв, **Ифер** 3:19 (Ифер 12:19). Хөшиг урагдаж мөн чи намайг харах болно, **С ба Г** 67:10 (С ба Г 38:8). Миний сүмийг хаах хөшиг авагдах болно, **С ба Г** 101:23. Бидний оюунаас хөшиг авагдсан байв, **С ба Г** 110:1. Харанхуйн хөшиг дэлхийг нөмрөх болно, **Моце** 7:61.

ХРИСТ. Есүс Христийг үз

ХРИСТИЙГ ЭСЭРГҮҮЦЭГЧ.

Чөтгөрийг *мөн үз*

Үнэн сайн мэдээний авралын төлөвлөгөөг хуурамчаар дуурайдаг, түүнчлэн Христтэй ил буюу далд сөргөлддөг ямар нэг юм буюу хүн. Илчлэгч Иохан Христийн эсрэг гэдгийг мэхлэгч хэмээн дүрсэлжээ (1 Иох. 2:18–22; 4:3–6; 2 Иох. 1:7). Люсифер бол агуу их Христийн эсрэг

хүн боловч түүнд сүнстэй болон махан биетэй олон туслагч бий.

Бурхан хэмээн дууддаг бүхнийг Мөхлийн хүү эсэргүүцэж мөн тэдний дээр өөрийгөө өргөдөг, **2 Тес.** 2:1–12. Тэрээр газар дэлхий дээр суугчдыг ид шидээр хууран мэхэлжээ, **Илч.** 13:13–17. Шерем Христийг үгүйсгэж олныг мэхлэв, **Иаков** 7:1–23. Нехор хуурамч сургаал зааж, сүм байгуулж, мөн санваараар мэргэших аргыг танилцуулав, **Алма** 1:2–16. Корихор Христийг, Цагаатгалыг мөн бошиглолын суу билгийг дооглов, **Алма** 30:6–60.

ХРИСТИЙН ХҮҮХДҮҮД.

Бурханаас төрөх; Бурханы хөвгүүд охид; Дахин төрөх; Есүс Христ; Төрөхийг мөн үз

Есүс Христийн сайн мэдээг хүлээн зөвшөөрсөн хүмүүс.

Хэн өөрийгөө энэ хүүхэд адил даруу болгоно, тэр нь хамгийн агуу нь болно, **Мат.** 18:1–4. Гэрэлд итгэгтүн, тэгвэл та нар гэрлийн хөвгүүд болно, **Иохан** 12:36. Эгэл хүнээ хаяж мөн хүүхэд адил бол, **Моз.** 3:19; 27:25–26. Гэрээний учир та нар Христийн хүүхдүүд хэмээн нэрлэгдэх болно, **Моз.** 5:7. Хэрэв та нар сайн зүйл болгоноос барих аваас, та нар гарцаагүй Христийн хүүхдүүд байх болно, **Моро.** 7:19. Намайг хүлээн авсан болгонд миний хүүхдүүд болох хүчийг би өгнө, **С ба Г** 39:4. Бүү эмээ, бяцхан хүүхдүүд, учир нь та нар минийх, **С ба Г** 50:40–41. Чибээр надад нэг, Бурханы хүү билээ, **Мосе** 6:68.

ХРИСТИЙНХЭН. Гэгээнтэн;

Шавийг мөн үз

Есүс Христэд итгэгчдэд өгсөн нэр. Хэдийгээр энэ нэр томъёо дэлхий даяар нийтлэг хэрэглэгддэг боловч Христийн үнэнч дагалдагчдыг Их Эзэн Гэгээнтнүүд хэмээн тодорхойлжээ (Үйлс 9:13, 32, 41; 1 Кор 1:2; С ба Г 115:4).

Шавь нарыг Христийнхэн хэмээн

нэрлэв, **Үйлс** 11:26. Хэрэв хэн нэгэн Христийнх гэдгээсээ болж зовдог бол бүү ич, **1 Петр** 4:16. Гэрээний учир та нар Христийн хүүхдүүд хэмээн нэрлэгдэх болно, **Моз.** 5:7. Жинхэнэ итгэгчид Сүмийн гишүүн бус тэднээр Христийнхэн хэмээн нэрлэгддэг байв, **Алма** 46:13–16.

ХРИСТИЙН СУРГААЛ.

Гэтэлгэлийн төлөвлөгөө;

Сайн мэдээг мөн үз

Есүс Христийн сайн мэдээний зарчмууд болон заадаг зүйлүүд.

Миний сургаал бороо адил дусална, **Дэд хууль** 32:2. Бувтналдах тэд сургаалыг сурах болно, **Иса.** 29:24. Түүний сургаалд хүмүүс гайхан шагширч байв, **Мат.** 7:28. Миний сургаал бол минийх биш харин намайг илгээсэн түүнийх, **Иохан** 7:16. Бүх судрууд сургаалд тустай, **2 Тим.** 3:16. Энэ бол Христийн сургаал, мөн Эцэгийн цорын ганц сургаал болой, **2 Ниф.** 31:21 (2 Ниф. 32:6). Сургаалуудын минь заалтуудын талаар та нарын дунд сөргөлдөөнүүд байх ёсгүй, **3 Ниф.** 11:28; 32, 35, 39–40. Сатан миний номлолын хэсгүүдийн талаар хүмүүсийн зүрх сэтгэлийг сөргөлдөөнд өдөөн хатгадаг билээ, **С ба Г** 10:62–63, 67. Хүүхдүүдэд наманчлалын сургаал, Христэд итгэх итгэл, баптисм, мөн Ариун Сүнсний бэлгийг заагтун, **С ба Г** 68:25. Бие биеэндээ хаант улсын сургаалуудыг заа, **С ба Г** 88:77–78. Санваарын сургаал чиний сүнсэнд нэрэгдэх болно (товч болгогдох болно), **С ба Г** 121:45.

ХУВИРАЛТ. Есүс Христ;

Санваарын түлхүүрүүдийг

мөн үз

Гадаад төрх байдал болон мөн чанараа түр зуур өөрчилсөн хүмүүсийн нөхцөл байдал—энэ нь тэнгэрлэг хүмүүсийн оршихуй хийгээд алдар сууг олж болохын тулд тэд сүнсний илүү өндөр түвшинд өргөгдөнө гэсэн үг.

Христийн хувиралт: Их Эзэн тэдний

өмнө сүр жавхлантай болж хувирахыг Петр, Иаков, Иохан харжээ. Петрт хаант улсын түлхүүрүүдийг хүлээн авах болно хэмээн Аврагч урьд нь амлажээ (Мат. 16:13–19; 17:1–9; Марк 9:2–10; Лук 9:28–36; 2 Петр 1:16–18). Энэ чухал үйл явдлаар Аврагч, Мосе, Елиа (Елиа) нар санваарын амлагдсан түлхүүрүүдийг Петр, Иаков, Иохан нарт өгчээ. Есүсийг дээшлэн одсоны дараа эдгээр санваарын түлхүүрүүдээр Төлөөлөгчид хаант улсын ажлыг үргэлжлүүлэх хүчтэй болсон ажээ.

Хувиралтын уулан дээр Петр, Иаков, Иохан нар, бас хувиран өөрчлөгдсөн байлаа хэмээн Иосеф Смит заажээ. Тэд ирээдүйн сүр жавхалант байдалдаа гарч ирэх дэлхийн тухай үзэгдлийг үзсэн (С ба Г 63:20–21). Тэд хувирсан хүмүүс—Мосе, Елиа нарыг харсан бөгөөд Эцэгийн дуу хоолойг сонсчээ. “Энэ бол миний хайрт Хүү мөн; Түүнийг сонсогтун” хэмээн Эцэг хэлсэн ажээ (Мат. 17:5).

Хувирсан хүмүүн биес: Тэд Израилын Бурханыг харсан болой, **Ег.** 24:9–11. Түүнийг Бурхантай ярих үед нүүрний арьс нь гэрэлтэж байв, **Ег.** 34:29 (Марк 9:2–3). Есүсийн нүүр гялалзаж байв, **Мат.** 17:2 (Марк 9:2–3). Израил Мосегийн нүүрэн дэх цог жавхланг харж чадахгүй байв, **2 Кор.** 3:7. Аби-надайн царай үлэмж гэрлээр туяаран байв, **Моз.** 13:5–9. Тэд галаар байсан мэт хүрээлэгдэв, **Хил.** 5:23, 36, 43–45 (3 Ниф. 17:24; 19:14). Тэд Есүсийн төрх шиг цагаан байв, **3 Ниф.** 19:25. Энэ нь тэдэнд хувирал мэт санагдав, **3 Ниф.** 28:15. Сүнсээр амилуулагдахаас бусдаар Бурханыг махан бодид харсан хүмүүн гэж үгүй бөлгөө, **С ба Г** 67:10–12. Сүнсний хүчээр бидний нүд нээгдсэн байв, **С ба Г** 76:12. Бурханы алдар суу Мосе дээр байв, **Мосе** 1:2. Түүний алдар суу миний дээр байв; мөн би түүний царайг харав, учир нь би өөрчлөгдсөн байв, **Мосе** 1:11. Би тэнгэр нээгдсэн байхыг харав, мөн би алдар суугаар хувцасласан байв, **Мосе** 7:3–4.

ХУДАЛ ХЭЛЭХ. Заль мэх; Мэхлэх; Хууран мэхлэх, Хилэнцгийг ярих; Шударга, Шударга ёсыг мөн үз

Залилан мэхлэх зорилго бүхий аливаа худал хуурмаг буюу үнэн биш мэдээлэл дамжуулах.

Та нар хулгай хийх, хуурамчаар үйлдэх, худал хэлэх ёсгүй, **Лев.** 19:11. Би худал хуурмагийг үзэн ядаж, жигшдэг, **Дуул.** 119:163. Худалч уруул ЭЗЭНий жигшлийг төрүүлдэг, **Сур.** үгс 12:22. Худал хэлдэггүй тэд миний хүмүүс билээ, **Иса.** 63:8. Чөтгөр бол худалч бөгөөд худал хуурмагийн эцэг, **Иохан** 8:44 (2 Ниф. 2:18; Ифер 8:25; Мосе 4:4). Чи хүнд биш, харин Бурханд худал хэллээ, **Үйлс** 5:4 (Алма 12:3). Хэрэв хэн нэг нь би Бурханыг хайрладаг гэж хэлчихээд, ах дүүгээ үзэн яддаг бол тэр хүн худалч, **1 Иохан** 4:20. Бүх худалч хүмүүсийн хувьд тэдэнд ноогдох хувь нь хоёр дахь үхэлд буй, **Илч.** 21:8 (С ба Г 63:17). Худалчид халаг, учир нь тэрээр доош тамд хаягдах болно, **2 Ниф.** 9:34. Бяцхан худал хэл, үүнд хор хөнөөл гэж үгүй хэмээн хэлж хуурмаг номлолыг олон нь заах болно, **2 Ниф.** 28:8–9 (С ба Г 10:25). Та нар Их Эзэнд худал хэлж чадна хэмээн төсөөлдөг үү? **Алма** 5:17. Та бол үнэний Бурхан бөгөөд худал хэлж эс чадна, **Ифер** 3:12 (Тоол. 23:19; 1 Сам. 15:29; Тит 1:2; Евр. 6:18; Инос 1:6). Худал хэлдэг бөгөөд эс наманчилдаг тэрээр зайлуулагдах болно, **С ба Г** 42:21. Худалчид телестиел алдар сууг өвлөдөг, **С ба Г** 76:81, 103–106. Шударга байхад бид итгэдэг, **ИТ** 1:13.

ХУЙВАЛДААН. Нууц хуйвалдааныг үз

ХУЛГАЙ, ХУЛГАЙЛАХ.

Бусдаас ямар нэг зүйлийг шударга бусаар буюу хууль бусаар авах. Их Эзэн хулгай бүү хий хэмээн өөрийнхөө хүүхдүүдэд байнга зарлигладаг байв (Ег. 20:15; Мат. 19:18; 2 Ниф. 26:32; Моз. 13:22; С ба Г 59:6).

Хулгайч эвдэж ордоггүй, хулгайлдаггүй тэнгэрт эд баялаг хураа, **Мат.** 6:19–21. Бардамналын учир, баялгийн учир, дээрэм тонуулын учир, хулгайн учир нифайчууд ялагдав, **Хил.** 4:12. Хулгай хийсэн тэрээр наманчлахгүй аваас, зайлуулагдах болно, **С ба Г** 42:20. Хулгай хийсэн тэд уг нутгийн хуулинд аваачигдах ёстой, **С ба Г** 42:84–85.

ХУУЛИЙН БАГШ

Хуучин мөн Шинэ Гэрээнд энэ нэр томьёог бага зэрэг ялгаатай хэрэглэдэг: (1) Хуучин гэрээнд, хуулийн багшийн гол үүрэг нь судруудыг хувилах байв (Иер. 8:8). (2) Хуулийн багш нар Шинэ Гэрээнд олонтаа дурдагддаг бөгөөд заримдаа хуульчид буюу хуулийн докторууд хэмээн нэрлэгддэг байв. Тэд хуулийг нарийвчлан хөгжүүлж өөрсдийнхөө цаг үеийн нөхцөл байдалд тохируулан ашигладаг байв (Мат. 13:52; Марк 2:16–17; 11:17–18; Лук 11:44–53; 20:46–47).

ХУУЛЬ. Адислагдсан, Адислал, Адислах; Бурханы зарлигууд; Дуулгавартай байдал; Дуулгавартай, Дуулгавартай дагах; Мосегийн хуулийг
мөн үз

Тэнгэр, газар дэлхий аль алин дээр нь бүх адислалууд хийгээд шийтгэлүүд дээр нь тулгуурладаг Бурханы зарлигууд буюу дүрэм журмууд. Бурханы хуулиудыг дуулгавартай дагадаг хүмүүс амлагдсан адислалуудыг хүлээн авдаг. Түүнчлэн хүмүүс улс орныхоо хуулиудыг дуулгавартай дагаж, дээдлэн хүндэлж, мөн дэмжих ёстой хэмээн Бошиглогч Иосеф Смит сургасан байдаг (ИТ 1:12).

Мосегийн хууль бол эрэгтэйчүүд түүнчлэн эмэгтэйчүүдийг Христэд авчрахад бэлтгэх хууль байв. Энэ бол хязгаарлалтууд, зааврууд түүнчлэн ёслолуудын хууль байлаа. Өнөөдөр, Мосегийн хуулийг гүйцэлдүүлсэн Христийн хууль нь бүрэн сайн

мэдээ буюу “эрх чөлөөний төгс хууль” мөн (Иаков 1:25).

Бурхан Адамд зарлигуудыг өгөв, **Эхл.** 1:28, 2:16–17. Бурхан Ноад хуулиудыг өгөв, **Эхл.** 9:1. Эзэний хууль нь төгс төгөлдөр, сэтгэлийг сэргээдэг, **Дуул.** 19:7. ЭЗЭН бол бидний хууль тогтоогч, **Иса.** 33:22. Хууль тогтоогч нэг л байдаг, **Иаков** 4:12. Хуульгүй газарт шийтгэл гэж үгүй, **2 Ниф.** 9:25. Хууль өгөгдөв, **Алма** 42:17–22. Хүмүүн хуулийн дагуу шүүгдэх болно, **Алма** 42:23. Христ бол хууль мөн, **3 Ниф.** 15:9. Бүх хуулиуд сүнслэг байдаг, **С ба Г** 29:34. Иосеф Смит Сүмийн хуулийг илчлэлтээр хүлээн авав, **С ба Г** 42. Бурханы хуулийг сахидаг хүн улс орныхоо хуулийг зөрчих шаардлагагүй, **С ба Г** 58:21. Христийн гэрэл бол бүх зүйл үүгээр удирдагддаг хууль мөн, **С ба Г** 88:7–13. Тэрээр бүх зүйлд хууль өгөв, **С ба Г** 88:42–43. Хүмүүс улс орныхоо хуулийг сахих ёстой, **С ба Г** 98:4–5. Бид Бурханаас адислал хүлээж авахад, энэ нь хуульд дуулгавартай байснаар ирдэг, **С ба Г** 130:20–21. Иргэний хуулиудын талаарх өөрийн итгэлийг Сүм тунхаглав, **С ба Г** 134. Хуулиуд хийгээд сайн мэдээний ёслолуудад дуулгавартай байснаар хүмүүн төрөлхтөн аврагддаг, **ИТ** 1:13.

ХУУЧИН ГЭРЭЭ. Библи;

Пентатеух; Судруудыг *мөн үз*

Ариун Сүнсний нөлөөн дор үйлдэн мөн Христ хийгээд түүний ирээдүйн тохинууллын тухай олон зууны туршид гэрчилж байсан эртний бошиглогчдын бичээсүүд. Энэ нь түүнчлэн Абрахамын түүхийн цэдэг хийгээд Абрахамаас эхлэн түүний үр удмууд, тэрчлэн Абрахам болон түүний үр удамтай Их Эзэний байгуулсан *гэрээг* агуулдаг.

Хуучин Гэрээний эхний таван номыг Мосе бичжээ. Эдгээр нь Эхлэл, Египетээс Гарсан нь, Левит, Тооллого, түүнчлэн Дэд Хууль юм. Эхлэлд дэлхий, хүн төрөлхтөн, хэлнүүд, үндэстэн арьстны эх үүсэл

түүнчлэн Израилын угсааны эхлэлийн тухай өгүүлдэг.

Түүхийн номнууд нь Израилын үйл явдлуудын тухай өгүүлдэг. Эдгээр номнууд бол Иошуа, Шүүгчид, Рут, 1 ба 2 Самуел, Хаадын Дээд ба Хаадын Дэд, Шастирын Дээд ба Шастирын Дэд, Езра, Иехемиа болон Естер болно.

Яруу найргийн номнууд нь бошиглогчдын зарим мэргэн ухаан хийгээд уран зохиолын цэдэг байдаг. Эдгээр нь Иов, Дуулал, Сургаалт Үгс, Номлогчийн Үгс, Соломоны Дуун, түүнчлэн Иеремиагийн Гашуудал юм.

Бошиглогчид Израилыг нүглүүдээс нь сэрэмжлүүлж түүнчлэн дуулгавартай байдлаас ирдэг адислалуудын тухай гэрчилдэг байв. Наманчилдаг, ёслолуудыг хүлээн авдаг, түүнчлэн сайн мэдээгээр амьдардаг хүмүүсийн нүглийг цагаатгахаар Христ ирэх тухай тэд бошиглодог байлаа. Бошиглогчдын номнууд гэвэл Исаиа, Иеремиа, Езекиел, Даниел, Хосеа, Иоел, Амос, Обадиа, Иона, Мика, Нахум, Хабаккук, Зефаниа, Хаггаи, Зехариа мөн Малахи болно.

Хуучин Гэрээний ихэнх номнууд еврей хэл дээр бичигджээ. Цөөн хэдэн ном арамей буюу холбогдох бусад хэлэн дээр бичигдсэн байдаг.

ХУЯГ ДУУЛГА

Биеийг цохилт болон зэвсгийн дүрэлтээс хамгаалан халхлах өмсгөл. Энэ үг нь мөн уруу таталт буюу хилэнцээс хүнийг хамгаалах сүнслэг чанар гэсэн утгаар хэрэглэгддэг.

Бурханы бүрэн хуяг дуулгыг өмсөгтүн, **Ефес** 6:10–18 (С ба Г 27:15–18).

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ.

Наманчлал, Наманчлах;
Өршөөх, Уучлахыг *мөн* үз

Судруудад хүлээн зөвшөөрөх гэдэг нь дор хаяж хоёр байдлаар хэрэглэгддэг. Нэг талаар, хүлээн зөвшөө-

рөх гэдэг нь Есүс бол Христ гэдгийг хүлээн зөвшөөрөхтэй (Мат. 10:32; Ром 10:9; 1 Иохан 4:1–3; С ба Г 88:104) адилаар, хэн нэгэн хүн ямар нэг итгэлтэйгээ нотлох явдал юм.

Нөгөө талаар, хүлээн зөвшөөрөх гэдэг нь нүглээ хүлээн зөвшөөрөхтэй адилаар, хүн өөрийн гэм бурууг хүлээн зөвшөөрөх явдал мөн. Бүх нүглээ Их Эзэний өмнө хүлээн зөвшөөрч, түүний өршөөлийг олж авах нь бүх хүмүүний үүрэг мөн (С ба Г 58:42–43). Шаардлагатай тохиолдолд, нэг хүн буюу эсвэл хүмүүсийн эсрэг үйлдэгдсэн нүглүүдийг хүлээн зөвшөөрөх ёстой. Ноцтой нүглүүдийг Сүмийн албан хаагчийн өмнө (ихэнх тохиолдолд бишоп) хүлээн зөвшөөрөх ёстой.

Тэрээр үйлдсэн нүглээ илчлэн хэлэх ёстой, **Лев.** 5:5. Тэд өөрсдийнхөө алдсыг хүлээн зөвшөөрөх болно, **Лев.** 26:40–42. Израилын Бурхан Их Эзэнд алдар сууг өг мөн түүнд нүглээ наманчил, **Иош.** 7:19. Тэд нүглээ улайгаад, Иордан голд түүгээр баптисм хүртэж байв, **Мат.** 3:5–6. Нүглүүдээ тоочигч зөрчигч өршөөгдөх болно, **Моз.** 26:29. Та нар шийтгэл амсахгүйн тулд нүглүүдээ хүлээцгээ, **С ба Г** 19:20. Наманчлагч нь нүглүүдээ хүлээж мөн бүрмөсөн орхих болно, **С ба Г** 58:43. Даруухан зүрхээр нүглүүдээ хүлээн зөвшөөрдөг тэдэнд Их Эзэн нигүүлсэнгүй ханддаг, **С ба Г** 61:2. Нүглүүдээ хүлээн зөвшөөрдөг мөн өршөөлийг асуудаг тэдний нүглийг Их Эзэн өршөөдөг, **С ба Г** 64:7.

ХҮН, ХҮМҮҮН, ХҮМҮҮС. Бурхан, Бурхан Тэргүүтэн; Бурханы хөвгүүд, охид; Сүнс; Сүнсний бүтээлтийг *мөн* үз

Бүх хүмүүн төрөлхтөн, эрэгтэй, эмэгтэй аль алинд нь хамаарна. Бүх эрэгтэйчүүд мөн эмэгтэйчүүд нь Тэнгэрлэг Эцэгийн шууд, сүнсний үр удам мөн. Тэд мөнх бус байдалд төрөхдөө мөнх бус биеийг хүлээн авдаг. Энэхүү бие нь Бурханы дүр төрхөөр бүтээгджээ (Эхл. 1:26–27).

Шаардлагатай ёслолуудыг хүлээн авч, тэдгээрийн гэрээнүүдийг сахих, түүнчлэн Бурханы зарлигуудыг дуулгавартай дагахад итгэлтэй байдаг эрэгтэйчүүд тэрчлэн эмэгтэйчүүд өөрсдийн өргөмжлөлд орж, Бурхан лугаа адил болдог.

Бурхан өөрийн дүр төрхөөр хүнийг бүтээжээ, **Эхл.** 1:27 (Моз. 7:27; С ба Г 20:17–18). Хүн гэгч юу болоод, та түүнд санаа тавина вэ? **Дуул.** 8:4–5. Хүмүүнд итгэж, бие махбодийг өөрийн хүч чадлаа болгодог хүн харагдсан билээ, **Иерем.** 17:5 (2 Ниф. 4:34; 28:26, 31). Би эрийн цээнд хүрээд хүүхэд насныхаа занг орхисон юм, **1 Кор.** 13:11. Тэд баясгалантай байж болохын тулд хүмүүн байх бөлгөө, **2 Ниф.** 2:25. Эгэл хүн бол Бурханы дайсан, **Моз.** 3:19. Та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ? **3 Ниф.** 27:27. Бурханы ажлууд бус, харин хүмүүний ажлууд хясагддаг бөлгөө, **С ба Г** 3:3. Та нар Бурханаас илүүгээр хүмүүнээс эмээх ёсгүй, **С ба Г** 3:7 (С ба Г 30:11; 122:9). Бүх зүйлүүд хүмүүний ашиг тусын тулд, түүгээр ашиглагдахын тулд бий болгогдсон билээ, **С ба Г** 59:18. Хүмүүн юу ч биш гэдгийг би мэднэ, **Мосе** 1:10. Бурханы ажил хийгээд алдар суу нь хүмүүний үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрах явдал мөн, **Мосе** 1:39.

Хүмүүн бол Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхэд мөн: Тэд нүүрээрээ унан, Бурхан, бүх махан биеийн сүнснүүдийн Бурхан гэв, **Тоол.** 16:22 (Тоол. 27:16). Та нар бол өөрсдийнхөө Бурхан Эзэний хөвгүүд юм, **Дэд хууль** 14:1. Та нар бол Бурхад, та нар бүгдээрээ Хамгийн Дээд Нэгэний хөвгүүд юм, **Дуул.** 82:6. Та нар амьд Бурханы хөвгүүд, **Хосеа** 1:10. Бид бүгд нэг эцэгтэй юм биш үү? Нэг Бурхан биднийг бүтээсэн юм биш үү? **Малах.** 2:10. Бид Бурханы үр удам, **Үйлс** 17:29. Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг Сүнс өөрөө бидний сүнснэй хамт гэрчилдэг, **Ром**

8:16. Сүнснүүдийн Эцэгт захирагдан амьдар, **Евр.** 12:9. Бүх хүмүүний сүнс нь тэдэнд амьдралыг өгсөн тэр Бурханд, гэртээ аваачигддаг, **Алма** 40:11. Дэлхийнүүдийн оршин суугчид бол Бурханы төрүүлсэн хөвгүүд, охид мөн, **С ба Г** 76:24. Хүмүүн эхлэлд Бурхантай хамт байв, **С ба Г** 93:23, 29. Дэлхийн гадаргуу дээр тэднийг байхаас өмнө бүх хүмүүнийг Бурхан сүнс байдлаар бүтээжээ, **Мосе** 3:5–7. Бибээр Бурхан бөлгөө; би дэлхийг, мөн тэд махан биеэр байхаас нь өмнө хүмүүнийг хийсэн билээ, **Мосе** 6:51.

Тэнгэрлэг Эцэгтэй адилхан болох боломж хүмүүнд буй: Тэнгэрлэг Эцэг тань төгс байдаг шиг та нар мөн төгс бай, **Мат.** 5:48 (3 Ниф.12:48). Тантай хуульд та нар бол бурхад юм гэж бичигдсэн байдаг биш үү? **Иохан** 10:34 (С ба Г 76:58). Бид Бурханы өв залгамжлагчид бөгөөд Христтэй хамтран залгамжлагчид юм, **Ром** 8:17. Чи хүү нь мөн, хэрэв хүү нь байх аваас Христээр дамжуулан Бурханы өв залгамжлагч нь мөн байна, **Гал.** 4:7. Түүнийг үзэгдэх үед бид түүнтэй адил болно гэдгийг мэднэ, **1 Иох.** 3:2. Надтай хамт миний сэнтийд залрахыг ялагчид соёрхон, **Илч.** 3:21. Тэдэнд би Бурханы хөвгүүд болохыг нь зөвшөөрсөн, **3 Ниф.** 9:17. Селестиел хаант улсыг өвлөх тэд бол бурхад, бүр Бурханы хүүхдүүд бөлгөө, **С ба Г** 76:50, 58. Тийнхүү тэдэнд бүх хүч байхын улмаас тэд бурхад байх болно, **С ба Г** 132:20.

ХҮНДЛЭЛ. Хүндэтгэл; Хүндэтгэл бишрэлийг мөн үз

Хэн нэгнийг буюу ямар нэг юмыг, ялангуяа сайн мэдээний хувьд, эрхэм үнэ цэнэтэй гэж үзэх.

Тэр үзэн ядагдаж, мөн бид түүнийг хүндэтгээгүй, **Иса.** 53:3–4. Хүмүүсийн эрхэмлэдэг зүйлс нь Бурханы мэлмийд жигшмээр юмс байдаг, **Лук** 16:15. Хүн бүр бусдыг өөрсдөөсөө дээр хэмээн хүндлэг, **Филип.** 2:3.

Их Эзэн бүх маханбодийг нэгэн адил хүндэтгэдэг, **1 Ниф.** 17:35. Хүн бүр хөршийгөө өөрийн адил хүндэтгэх ёстой, **Моз.** 27:4 (С ба Г 38:24–25). Энх амгалангийнхаа өдөр тэд миний зөвлөгөөг ялимгүй хүндэтгэдэг байв, **С ба Г** 101:8.

ХҮНДЭТГЭЛ. Бишрэн хүндлэх,

Хайр хүндлэлийг *мөн үз*

Судруудад ихэвчлэн хэрэглэгддэгээр, хэн нэгэнд эсвэл ямар нэг зүйлд хүндэтгэл буюу бишрэл хүндэтгэл үзүүлэх.

Эцэг эхээ хүндэл, **Ег.** 20:12 (1 Ниф. 17:55; Моз. 13:20). Эд хөрөнгөөрөө Эзэнийг дээдэл, **Сур.** үгс 3:9. Хэрэв хүн надад үйлчилбэл, түүнийг Эцэг минь хүндэлнэ, **Иохан** 12:26. Нөхрүүд нь эхнэрүүддээ хүндэтгэл үзүүлэх ёстой, **1 Петр** 3:7. Тэд зөвхөн уруулаараа л Их Эзэнийг хүндэлдэг, **2 Ниф.** 27:25 (Иса. 29:13). Би дэлхийн нэр төрийг эрэлхийлдэггүй, **Алма** 60:36. Миний хүч болох алдар хүндээ надад өг хэмээн чөтгөр миний эсрэг босов, **С ба Г** 29:36. Итгэлтнүүд алдар хүндэтгэлийн титэм өмсөх болно, **С ба Г** 75:5 (С ба Г 124:55). Их Эзэн өөртөө үйлчилдэг тэднийг хүндлэхдээ баяртай байдаг, **С ба Г** 76:5. Тэд хүмүүсээс хүндэтгэл хүлээхийг эрмэлздэг учир сонгогдоогүй билээ, **С ба Г** 121:34–35. Хуулийг хүндлэн дээдэлж дэмжих ёстой гэдэгт бид итгэдэг, **ИТ** 1:12 (С ба Г 134:6).

ХҮНДЭТГЭЛ БИШРЭЛ. Айдас;

Хүндэтгэлийг *мөн үз*

Ариун нандин зүйлүүдийг гүнээ хүндлэх, сүрдэн бишрэх.

ЭЗЭН Мосед гутлаа тайлахыг зарлиглав, учир нь тэрээр ариун газар дээр зогсож байв, **Ег.** 3:4–5. Бурхан бол эмээхээр, мөн сүрдэн бишрэхээр бөлгөө, **Дуул.** 89:7. Хүндлэл хийгээд бурханлиг айдсаар, тааламжтай байдлаар Бурханд үйлчил, **Евр.** 12:28. Моронай газарт бөхийн сууж, хүчтэйгээр залбирав, **Алма**

46:13. Цугласан олон газар унаж, мөн Христийг шүтэн бишрэв, **3 Ниф.** 11:12–19. Миний өмнө бөхий **С ба Г** 5:24. Бүх зүйл Бурханы сэнтийн өмнө даруухан хүндэтгэлд бөхийдог, **С ба Г** 76:93. Итгэлгүйн улмаас, түүнчлэн та нар өөрсдийнхөө хүлээн авсан зүйлүүдэд хөнгөмсгөөр хандсаны улмаас оюун тань харанхуйлагдсан байна, **С ба Г** 84:54–57. Өвдөг бүхэн сөхөрч, мөн хэл болгон хүлээн зөвшөөрөх болно, **С ба Г** 88:104. Дээр Оршигчийн нэрийг хүндэтгэх буюу бишрэн хүндлэхээс үүдэн, Сүм санваарыг Мелкизедекийн нэрээр нэрлэсэн юм, **С ба Г** 107:4. Их Эзэнийг өөрийнх нь өргөлд бишрэн хүндэлдэг хүмүүс дээр адислалууд цутгагдах болно, **С ба Г** 109:21.

ХҮНДЭТГЭЛИЙН ӨДӨР. Амралт;

Бүтээлт, Бүтээхийг *мөн үз*

Амрах буюу шүтэн бишрэхэд зориулан онцгойлон адисласан долоо хоног бүрийн нэг ариун өдөр. Бурхан бүх зүйлийг бүтээсний дараа, тэрээр долоо дахь өдөр амарч, Өөрийг нь дурсан санахад хүмүүст туслахаар долоо хоногт нэг өдөр амрахыг зарлиглажээ (Ег. 20:8–11).

Христийн амилалтын өмнө Сүмийн гишүүд долоо хоногийн сүүлчийн өдрийг, иудейчүүдийн нэгэн адил Хүндэтгэлийн өдөр хэмээн даган мөрдөж байв. Амилалтын дараа Сүмийн гишүүд иудейчүүд болон харийнхан долоо хоногийн эхний өдрийг (Их Эзэний өдөр) Их Эзэний амилалтыг дурсан санах өдөр хэмээн даган мөрдөх болжээ. Өнөөдөр Сүм долоо хоногийн нэг өдрийг Бурханыг шүтэн бишрэх мөн дэлхийн хөдөлмөрөөсөө амрах хүндэтгэлийн ариун өдөр хэмээн даган мөрдөхөө үргэлжлүүлж байна.

Хүндэтгэлийн өдөр нь сүнслэг тэжээлийн хэрэгцээг нь болон Бурханыг дуулгавартай дагах үүргийг нь хүмүүст сануулж байдаг. Хүндэтгэлийн өдрийг сахихад улс үндэстэн хайхрамжгүй хандах юм бол, амьдралын бүх талд нь нөлөөлж,

шашны амьдрал нь доройтдог (Нех. 13:15–18; Иер. 17:21–27).

Бурхан долоо дахь өдөр амрав, **Эхл.** 2:1–3. Израилын хүүхдүүд хүндэтгэлийн өдөр маннаг цуглуулсангүй, **Ег.** 16:22–30. Хүндэтгэлийн өдрийг дурсан сана, үүнийг ариунаар сахь, **Ег.** 20:8–11 (Моз. 13:16–19). Хүндэтгэлийн өдөр нь Бурхан хүн хоёрын хооронд тэмдэг болон өгөгджээ, **Ег.** 31:12–17 (Езек. 20:12, 20). Хүндэтгэлийн өдөр бид худалдан авах буюу худалдах ёсгүй, **Нех.** 10:31. Хүндэтгэлийн өдрийг баясгалант хэмээн нэрлэ, Их Эзэнийг хүндэтгэн өөрийн таашаалыг бүү хай, **Иса.** 58:13–14. Хүндэтгэлийн өдөр нь хүний төлөө хийгдсэн бөгөөд хүн нь хүндэтгэлийн өдрийн төлөө бус болой, **Марк** 2:23–28. Хүний Хүү бол хүндэтгэлийн өдрийн Их Эзэн мөн, **Лук** 6:1–10. Есүс хүндэтгэлийн өдөр синагогт зааж мөн өвчтөнийг эдгээжээ, **Лук** 13:10–14. Нифайчууд хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахьдаг байв, **Жером** 1:5. Хүндэтгэлийн өдрийг сахьж үүнийг ариунаар нь хадгал, **Моз.** 18:23. Миний ариун өдөр ариун ёслолуудаа зориулан өргө, **С ба Г** 59:9–13. Сионы оршин суугчид хүндэтгэлийн өдрийг сахих ёстой, **С ба Г** 68:29. Бурхан бибээр долоо дахь өдөр бүх ажлуудаасаа амарсан билээ, **Моисе** 3:1–3 (**Эхл.** 2:1–3; **Абр.** 5:1–3).

ХҮНИЙ ХҮҮ. Бурхан, Бурхан

Тэргүүтэн; Есүс Христийг *мөн үз*

Есүс Христ өөрийнхөө тухай ярихдаа хэрэглэдэг байсан нэр (**Лук** 9:22; **Лук** 21:36). Энэ нь Ариун Хүний Хүү гэсэн утгатай байв. Ариун Хүн нь Бурхан Эцэгийн нэг нэр юм. Есүс өөрийгөө Хүний Хүү хэмээн нэрлэхэд энэ нь Эцэгтэй түүний тэнгэрлэг ургийн холбоотой илэрхий тунхаглал байв. Энэ нэр Сайн Мэдээнүүдэд олонтаа тохиолддог. Аврагчийн энэхүү нэрний өвөрмөц утга хийгээд ариун нандин чанарыг хожмын үеийн илчлэлт баталдаг (**С ба Г** 45:39; 49:6, 22; 58:65; **Моисе** 6:57).

ХҮРГЭН ХҮҮ. Есүс Христийг *мөн үз*

Сударт Есүс Христийг Хүргэн Хүү болгон бэлэгддэг. Сүм нь түүний бэлэгдлийн сүйт бүсгүй юм.

Арван онгон охин Хүргэн Хүүг угтахаар урагш явав, **Мат.** 25:1–13. Сүйт бүсгүйтэй тэр нь Хүргэн Хүү билээ, **Иохан** 3:27–30. Хурганы хуримын зоогонд уригдагсад ерөөлтэй еэ, **Илч.** 19:5–10. Хүргэн Хүүгийн ирэлтэд бэлэн байгтун, **С ба Г** 33:17. Хүргэн Хүүгийн тулд бэлэн болгогтун, **С ба Г** 65:3.

ХҮҮХДҮҮДИЙН АВРАЛ. Аврал—

Хүүхдүүдийн аврал; Хүүхэд, Хүүхдүүдийг *үз*

ХҮҮХЭД, ХҮҮХДҮҮД. Аврал—

Хүүхдүүдийн аврал; Адислал— Хүүхдүүдийн адислал, Адислагдсан, Адислах; Бага насны хүүхдүүдийн баптисм; Гэр бүл; Харгалзах; Хүндэтгэх; Цагаатгал, Цагаатгахыг *мөн үз*

Бэлгийн хөгжил нь гүйцээгүй залуу хүн. Эцэг эхчүүд хүүхдүүдээ Бурханы хүслийг дуулгавартай дагахад сургах ёстой. Хүүхдүүд хариуцлагын насанд хүртлээ нүгэлгүй байдаг (**Моро.** 8:22; **С ба Г** 68:27).

Хүүхдүүд нь Их Эзэнээс ирдэг бэлэг юм, **Дуул.** 127:3–5. Явах ёстой замаар нь замнуулахын тулд хүүхдийг сурга, **Сур.** үгс 22:6. Хүүхдүүдийг зөвшөөр, мөн над уруу ирэхийг нь бүү болиул, **Мат.** 19:14. Эцэг эхээ дуулгавартай дага, **Ефес** 6:1–3 (**Кол** 3:20). Уналтгүйгээр Адам Ева хоёр хүүхдүүдгүй байх сан, **2 Ниф.** 2:22–23. Үнэний мөн чанд байдлын замуудаар алхахыг хүүхдүүдэд заа, **Моз.** 4:14–15. Бяцхан хүүхдүүдэд мөнх амьдрал буй, **Моз.** 15:25. Есүс бяцхан хүүхдүүдийг авч тэднийг адислав, **3 Ниф.** 17:21. Бүх хүүхдүүд тань Их Эзэнээр сургагдах болно, мөн хүүхдүүдийн тань амар амгалан агуу их байх болно, **3 Ниф.** 22:13 (**Иса.** 54:13). Бяцхан хүүхдүүдэд наманчлал болон багтисм хэрэггүй,

Моро. 8:8–24. Бяцхан хүүхдүүд дэлхийн сууринаас миний Төрсөн Ганцаар дамжин гэтэлгэгдсэн билээ, **С ба Г** 29:46–47. Сайн мэдээний зарчмууд болон дадлуудыг эцэг эхчүүд хүүхдүүддээ заах ёстой, **С ба Г** 68:25, 27–28. Хүүхдүүд Христийн цагаатгалаар дамжин ариусгагддаг, **С ба Г** 74:7. Хүүхдүүдээ гэрэл болон үнэнд авчрахаар эцэг эхчүүд зарлигдуулжээ, **С ба Г** 93:40. Хариуцлагын наснаас өмнө нас барсан хүүхдүүд селестиел хаант улсад аврагддаг, **С ба Г** 137:10.

ХҮЧ. Санваар; Эрх мэдлийг *мөн үз*

Ямар нэг юмыг хийх чадвар. Хэн нэгний болон ямар нэг юмны талаар хүчтэй байна гэдэг нь тэрээр хүн буюу юмыг хянах буюу захирах чадвартай байна гэсэн үг. Судруудад хүч нь ихэвчлэн Бурханы хүч буюу тэнгэрийн хүчтэй холбоотой байдаг. Бурханы өмнөөс ажиллах зөвшөөрөл буюу эрх болох санваартны эрх мэдэлтэй энэ нь нягт холбоотой байдаг.

Энэ зорилгын учир өөрийн хүчийг чамд үзүүлэхийн тулд чамайг босгосон юм, **Ег.** 9:16. Бурхан бол миний чадал хийгээд хүч мөн, **2 Сам.** 22:33. Үүнийг үйлдэх хүч чиний гарт байгаа үед сайн бусаас татгалз, **Сур.** үгс 3:27. Үнэхээр би Их Эзэний сүнсний хүчээр дүүрэн байна, **Мика** 3:8. Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг надад өгсөн, **Маг.** 28:18. Түүний сургаал эрх мэдэлтэй байсан тул тэд сургаалыг нь гайхан шагшиж байлаа, **Лук** 4:32. Дээрээс ирэх хүчийг өмстлөө та нар энэ хотод үлд, **Лук** 24:49. Өөрийг нь хүлээн авсан болгонд, Бурханы хүүхдүүд болох эрхийг Тэр өгөв, **Иохан** 1:12. (С ба Г 11:30). Та нар хүчийг хүлээн авах болно, үүний дараа Ариун Сүнс та нар дээр ирнэ, **Үйлс** 1:8. Бурханаас бус аваас өөр эрх мэдэл гэж үгүй, **Ром** 13:1. Авралд итгэх итгэлээр дамжуулан та нар Бурханаас ирэх хүчээр хадгалагдан байдаг, **1 Петр** 1:3–5. Би Бурханы хүчээр дүүргэг-

дээд байна, **1 Ниф.** 17:48. Энэ нь Ариун Сүнсний хүчээр надад үзүүлэгдсэн болой, **Иаков** 7:12. Хүмүүнд агуу их хүч Бурханаас өгөгдөж болох бөлгөө, **Моз.** 8:16. Тэд Бурханы хүч хийгээд агуу эрх мэдэлтэйгээр зааж байлаа, **Алма** 17:2–3. Нифай хүч хийгээд агуу эрх мэдэлтэйгээр тохинуулж байв, **3 Ниф.** 7:15–20 (3 Ниф. 11:19–22). Хүн хүчирхэг ажлуудыг хийх эрх мэдэлтэй байж болох хэдий ч, хэрэв тэр өөрийн хүчинд эрдэн сагсуурвал, тэр унах болно, **С ба Г** 3:4. Сайныг үйлдэх хүч хүн болгонд байдаг, **С ба Г** 58:27–28. Мелкизедек санваарын ёслолуудад бурханлиг чанарын хүч үзүүлэгддэг, **С ба Г** 84:19–22. Санваарын эрхүүд нь тэнгэрийн хүчнүүдтэй салшгүй холбоотой юм, **С ба Г** 121:34–46. Би чамайг гараараа хөтлөх болно, мөн миний хүч чам дээр байх болно, **Абр.** 1:18.

ХЭЛ

Харилцааны мэдээлэл, бодол санаа, үзэл бодлуудыг илэрхийлэхийн тулд бичигдсэн буюу хэлэгдсэн үгсийг тусгай загвараар хамтад нь байрлуулах үйл явц. Хэлийг бид хэрхэн хэрэглэснээр Бурхан болон бусад хүмүүст бид хэрхэн хандаж байгаагаа мэдэрдэг. Есүс Христийн Хоёр дахь Ирэлтээр Их Эзэн бүх хүмүүн төрөлхтөнд цэвэр хэл өгөх болно (**Зеф.** 3:8–9).

Бүх дэлхий нэг хэлтэй байв, **Эхл.** 11:1. ЭЗЭН бүх дэлхийн хэлийг будлиулав, **Эхл.** 11:4–9. Хүн бүр тэднийг өөрийнх нь хэлээр ярихыг сонсов, **Үйлс** 2:1–6. Их Эзэн хүмүүнд өөрсдийнх нь хэлний дагуу ярьдаг, **2 Ниф.** 31:3 (С ба Г 1:24). Өөрийнх нь хөвгүүд ойлголтыг агуулсан хүмүүс болж болохын тулд Бенжамин тэдэнд эцэг өвгөдийнхөө хэлийг заадаг байв, **Моз.** 1:2–5. Хэл нь даруухан, мөн сэнхрүүлдэг тэрээр, хэрэв тэр миний ёслолуудыг дуулгавартай дагах аваас, Бурханых бөлгөө, **С ба Г** 52:16. Хэлнүүд, мөн хүмүүстэй танилц, **С ба Г** 90:15. Адам болон

түүний хүүхдүүд цэвэр, мөн бузарлагдаагүй хэлтэй байв, **Мосе** 6:5–6, 46. Бурхан Еноход хэлний агуу хүчийг өгчээ, **Мосе** 7:13.

ХЭЛ ЯРИА. Хэлний бэлгүүдийг

мөн үз

Ярианы бэлэгдэл. Гэгээнтнүүд өөрсдийн хэлийг хянах ёстой, тэд хэл яриагаа хянаж байх ёстой гэсэн утгатай. Хэл нь тэрчлэн хэл яриа хийгээд хүмүүсийг хамруулдаг. Эцсийн эцэст өвдөг бүхэн Бурханд сөхөрч, мөн хэл бүхэн хүлээн зөвшөөрөх болно (Иса. 45:23; Ром 14:11).

Өөрийн хэлийг хорон муугаас сахин хамгаал, **Дуул.** 34:13 (1 Петр 3:10). Ам хэлээ захирдаг хүн аюулаас сэтгэлээ хамгаална, **Сур. үгс** 21:23. Хэрэв хэн нэгэн нь хэл амаа хазаарладаггүй бол шүтлэг нь ашиггүй ажээ, **Иаков** 1:26. Хэрэв хэлэх үгэн дээрээ бүдэрдэггүй хүн байвал тэр нь төгс хүн юм, **Иаков** 3:1–13. Сайн мэдээ нь бүх үндэстэн ястан, хэлтэн, мөн хүмүүст номлогдох болно, **Илч.** 14:6–7 (2 Ниф. 26:13; Моз. 3:13, 20; С ба Г 88:103; 112:1). Их Эзэн бүх үндэстнүүдэд өөрийн үгийг заах заримыг тэдний өөрсдийнх нь үндэстэн мөн хэлтнээс өгдөг, **Алма** 29:8. Эдгээр ялтаснууд бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүст очих болно, **Алма** 37:4. Миний үгийг олж ав, тэгвэл хэл чинь чөлөөтэй болно, **С ба Г** 11:21. Хүн бүр сайн мэдээний бүрэн байдлыг өөрийн төрөлх хэлээр сонсох болно, **С ба Г** 90:11.

ХЭЛНИЙ БЭЛГҮҮД. Сүнсний

бэлгүүд; Хэлийг мөн үз

Ариун Сүнсний бэлэг нь мэдэхгүй хэлнүүдээр ярих, ойлгох буюу хөрвүүлэх боломжийг бурханлигаар нөлөөлөгдсөн хувь хүнд олгодог. Хэлний бэлгүүдэд бид итгэдэг (ИТ 1:7).

Тэд Ариун Сүнсээр дүүрч, харь хэлээр ярьж эхлэв, **Үйлс** 2:4. Мэдэхгүй хэлээр ярьдаг хүн хүнд бус, Бурханд ярьдаг, **1 Кор.** 14:1–5, 27–28. Хэлнүүд нь итгэдэггүй хүмүүсийн төлөөх тэмдэг юм, **1 Кор.** 14:22–28.

Тэгээд галын мөн Ариун Сүнсний баталгаа ирдэг; мөн тэгээд тэнгэр элчүүдийн хэлээр ярьж чадна, **2 Ниф.** 31:13–14. Амалекай хэлээр ярих бэлэгт итгэхийг бүх хүмүүст ятгав, **Омнай** 1:25. Мөн дахин, хэлнүүдээр ярих нь заримд нь; мөн хэлнүүдийн хөрвүүлэг нь өөр нэгэнд нь өгөгддөг болой, **С ба Г** 46:24–25 (1 Кор. 12:10; Моро. 10:8, 15–16). Хэлний бэлэг юүлэгдэг, **С ба Г** 109:36.

ХЭРҮҮЛ. Зөрчлийг үз

ЦАГААТГАХ, ЦАГААТГАЛ.

Аврал; Адам Ева хоёрын Уналт; Амилуулалт; Ариун ёслол; Ариусгал; Ач ивээл; Бурханы охид хөвгүүд; Гетсемани; Гэтэлгэгдсэн, Гэтэлгэл, Гэтэлгэх; Гэтэлгэлийн төлөвлөгөө; Есүс Христ; Загалмай; Золиослол; Зөвтгөл, Зөвтгөх; Наманчлал, Наманчлах; Нигүүлсэл, Нигүүлсэнгүй; Нүглүүдийн ангижрал; Өршөөх, уучлах; Үхэшгүй, Үхэшгүй байдал; Христийн хүүхдүүд; Цовдлолт; Цусыг *мөн үз*

Хүмүүнийг Бурханд нийцүүлэх.

Судруудад хэрэглэгдсэнээр, цагаатгах гэдэг нь нүглийн үйлийн төлөө шийтгэл амсч, ингэснээрээ нүглийн үрийг наманчлагч нүгэлтнээс зайлуулж, Бурханд нийцэх боломжийг түүнд олгодог байна. Есүс Христ бол бүх хүн төрөлхтний төлөө төгс цагаатгал хийж чадах тэрхүү цорын ганц хүн юм. Тэрээр дэлхий үүсэхээс өмнө өөрийн бурханлиг Хүүгийн, түүнчлэн өөрийн нүгэлгүй амьдралын учир Их Зөвлөл дээр сонгогдож мөн урьдчилан томилогдсон учраас үүнийг гүйцэтгэх чадвартай байсан бөлгөө (Ифер 3:14; Мосе 4:1–2; Абр. 3:27). Түүний цагаатгал хүн төрөлхтний нүглүүдийн төлөө Гетсеманийн Цэцэрлэгт шаналан зовж, цусаа урсган, улмаар амь насаа алдаж, дараа нь булшнаас амилагдсаных багтаадаг (Иса.53:3–12;

Моз.3:5–11; Алма 7:10–13). Цагаатгалын улмаас бүх хүмүүс үхэшгүй биетэйгээр нас барагсдаас босч ирэх болно (1 Кор. 15:22). Түүнчлэн Цагаатгал нь нүглүүдээсээ өршөөгдөж, Бурхантай хамт үүрд амьдрах замыг тэдэнд хангаж өгдөг билээ. Харин хариуцлагын насанд хүрч, хуулийг хүлээн авсан хүн, хэрэв тэрээр Есүс Христэд итгэх итгэлтэй байж, нүглээ наманчлан, авралын ёслолуудыг хүлээн авч, түүнчлэн Бурханы зарлигуудыг дагасан тохиолдолд л гагцхүү эдгээр адислалуудыг хүлээн авч чадна. Хариуцлагын насанд хүрээгүй хүмүүс түүнчлэн хуульгүй тэд Цагаатгалаар дамжин гэтэлгэгддэг бөлгөө (Моз. 15:24–25; Моро. 8:22). Хэрэв Христ бидний нүглүүдийн төлөө цагаатгал хийгээгүй бол хууль ч, ёслол ч, эсвээс золиослол ч шударга ёсны шаардлагуудыг хангаж чадахгүй байсан, мөн хүмүүн Бурханы дэргэд дахин хэзээ ч очиж чадахгүй болох байсныг судрууд тодорхой заадаг билээ (2 Ниф. 2; 9).

Энэ бол нүглүүдийн уучлалын тул олны төлөө урсгах миний цус, **Мат.** 26:28. Түүний хөлс цусны дусал адил байв, **Лук** 22:39–44. Дэлхийн амийн төлөө би өөрийнхөө махан биеийг өгье, **Иохан** 6:51. Би бол амилалт хийгээд амьдрал билээ, **Иохан** 11:25. Христ бол дуулгавартай хүмүүсийн мөнхийн авралын үндэс болсон, **Евр.** 5:9. Христийн урсгасан цусаар бид ариусгагддаг, **Евр** 9; 10:1–10. Христ мөн нүглийн төлөө зовсон, **1 Петр** 3:18. Есүс Христийн цус биднийг бүх нүглээс ангижруулдаг, **1 Иох.** 1:7. Тэрээр загалмайд өргөгдөн мөн нүглүүдийн тул алагдсан юм, **1 Ниф.** 11:32–33. Харууссан зүрх мөн гэмшсэн сэтгэлтэй хүмүүст Гэтэлгэл ирнэ, **2 Ниф.** 2:3–10, 25–27. Тэрбээр өөрийгөө нүглийн золиослол болгон өргөжээ, **2 Ниф.** 2:7. Цагаатгал хүмүүнийг уналтаас чөлөөлж мөн тэднийг үхэл болон тамаас аварсан, **2 Ниф.** 9:5–24. Хязгааргүй цагаатгал байх нь зайлшгүй, **2 Ниф.** 9:7. Христийн цагаатгалаар

Бурхантай нийцсэн бай, **Иаков** 4:11. Мэдээгүйн улмаас нүгэл үйлдсэн тэдний нүглүүдийг Түүний цус цагаатгах болно, **Моз.** 3:11–18. Цагаатгалаар дамжуулан хүмүүн авралыг хүлээн авсан билээ, **Моз.** 4:6–8. Цагаатгал үгүй аваас тэд гарах аргагүйгээр мөхөх болно, **Моз.** 13:27–32. Тэрээр дэлхийн нүглийг цагаатгах болно, **Алма** 34:8–16. Нигүүлсэнгүйн төлөвлөгөөг авчрахын тулд Бурхан өөрөө дэлхийн нүглүүдийг цагаатгах болно, **Алма** 42:11–30. Бибээр бүх л дэлхийн Бурхан, мөн дэлхийнхний нүглүүдийн төлөө алагдсан болой, **3 Ниф.** 11:14. Бурхан бибээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг амссан юм, **С ба Г** 19:16. Бяцхан хүүхдүүд миний Төрсөн Ганцаар дамжин гэтэлгэгддэг, **С ба Г** 29:46–47. Нүгэл үйлдээгүй түүний зовлон хийгээд үхлийг болгоогтун, **С ба Г** 45:3–5. Энэ зүйл бол Төрсөн Ганцын золиослолтой адил, **Моисе** 5:7. Христийн Цагаатгалаар дамжуулан бүх хүн төрөлхтөн аврагдана, **ИТ** 1:3.

ЦАГ ХУГАЦААНЫ ТЭМДГҮҮД.

Есүс Христийн Хоёр дахь Ирэлт; Тэмдэг Хожмын өдрүүдийг *мөн үз*

Өөрийнх нь ажилд тохиосон буюу удахгүй тохиох ямар нэг чухал зүйлийг үзүүлэхээр Бурхан хүмүүст өгдөг үйл явдлуудаар Хожмын өдрүүдэд Аврагчийн хоёр дахь ирэлтийн талаарх олон тэмдгүүд бошиглогдсон билээ. Эдгээр тэмдгүүд Бурханы төлөвлөгөөг хүлээн зөвшөөрч, сэргэмжлүүлэгдэн, улмаар бэлтгэх боломжийг итгэлтэй хүмүүст олгодог.

Их Эзэний уул, толгодын дээгүүр өргөгдөнө, **Иса.** 2:2–3. Их Эзэн туг өргөж, Израилыг цуглуулна, **Иса.** 2:26 (2 Ниф. 15:26–30). Нар харанхуйлж, мөн сар гэрлээ өгөхөөс татгалзана, **Иса.** 13:10 (Жоел 3:15; С ба Г 29:14). Хүн хуульд нүгэл үйлдэж мөн үүрдийн гэрээг зөрчдөг, **Иса.** 24:5. Нифайчууд шороон дотроос ярих болно, **Иса.** 29:4 (2 Ниф. 27). Израил тэнгэрийн хүчээр нэгтгэгдэх бол-

но, **Иса.** 49:22–23 (1 Ниф. 21:22–23; 3 Ниф. 20–21). Хэзээ ч устгагдах нь үгүй нэгэн хаанчлалыг Бурхан байгуулах болно, **Иоел** 2. Бүх үндэстнүүд Иерусалимын эсрэг тулалдаанд нэгдэх болно, **Зех.** 14:2 (Езек. 38–39). Зуух мэт шатах өдөр ирнэ, **Малах.** 4:1 (3 Ниф. 25:1; **С ба Г** 133:64; **ИС**—**Т** 1:37). Хоёрдахь Ирэлтийн өмнө агуу гамшгууд тохиох болно, **Мат.** 24: (ИС—**Мат.** 1). Урвалт болон эцсийн өдрүүдийн гамшгуудыг Паул дүрслэв, **2 Тим.** 3–4. Иерусалимд хоёр бошиглогч алагад мөн амилуулагдах болно, **Илч.** 11 (С ба Г 77:15). Эцсийн өдрүүдэд сайн мэдээ тэнгэр элчийн тохинууллаар сэргээгдэх болно, **Илч.** 14:6–7 (С ба Г 13; 27; 110:11–16; 128:8–24). Вавилон үндэслэгдэн байгуулагдаж, мөн унах болно, **Илч.** 17–18. Израил тэнгэрийн хчээр цугларах болно, **1 Ниф.** 21:13–26 (Иса. 49:13–26; 3 Ниф. 20–21). Энэ бол та нар цагийг мэдэж болох тэрхүү тэмдэг булно, **С ба Г** 63:32–35 (Илч. 9). Бүх үндэстнээр дайн тархах болно, **С ба Г** 87:2. Тэмдгүүд, элементүүдийн өөрчлөлт, мөн тэнгэр элчүүд Их Эзэний ирэлтийн замыг бэлтгэнэ, **С ба Г** 88:86–94. Дэлхийг харанхуй нөмрөх болно, **С ба Г** 112:23–24. Хоёрдахь Ирэлтэнд бэлтгэхийг Их Эзэн Гэгээнтнүүдэд зарлигаар, **С ба Г** 133.

ЦЕЗАРЬ

Шинэ Гэрээнд Ромын зарим эзэн хаадын нийтлэг нэр. Сударт үүнийг дэлхийн засаглал болон хүчний бэлэгдэл болгон хэрэглэдэг.

Цезарийн юмыг Цезарьт буцаан өг, **Мат.** 22:21 (Марк 12:17; Лук 20:25; С ба Г 63:26).

ЦОВДЛОЛТ. Голгота; Есүс Христ;
Загалмай; Цагаатгал,
Цагаатгахыг мөн үз

Шинэ Гэрээний үед нийтлэг байсан хүнийг гар болон хөлийг нь загалмайд уях буюу хадаж үхэлд хүргэдэг Ромын цаазаар авах хэлбэр. Үүнийг ихэнхдээ зөвхөн боолууд болон хамгийн дорд гэмт хэрэгтнүүдэд хийдэг байв.

Ихэнхдээ цовдлуулахын өмнө ташуурдуулах буюу ороолгуулдаг (Марк 15:15). Цовдлуулах гэж буй хүнээр загалмайг нь ихэвчлэн цаазлах газар уруу өөрөөр нь авч явуулдаг (Иохан 19:16–17). Хувцсыг нь ялыг гүйцэтгэсэн цэргүүд авдаг байв (Мат. 27:35). Загалмай нь хүний хөл газраас 30-60 см өндөрт байхаар газарт булагдсан байдаг. Загалмайн дээрх хүнийг үхтэл нь цэргүүд харгалздаг байсан бөгөөд заримдаа энэ нь гурав хүртэл өдөр болдог байв (Иохан 19:31–37).

Итгэлгүй бүлэг хүмүүс Есүс бурууг үйлдсэн хэмээн, Цезарийн эсрэг үймээн дэгдээж өөрийгөө Бурханы Хүү хэмээн Бурханыг доромжилсон гэж хуурмагаар мэдүүлсэн учраас Есүс Христ цовдлуулсан юм. Есүст ягаан нөмрөг (Иохан 19:2), өргөст титэм өмсгөж бас бусад хэлбэрээр доромжилжээ (Мат. 26:67; Марк 14:65).

Мессиагийн гар хөлд хилэнцтэнгүүд мөхөх болно, **Дуул.** 22:11–18. Христ хурга адил хяргагч уруу явна, **Иса.** 53:7. Есүс өөрийнхөө цовдлуулалтыг урьдчилан хэлэв, **Мат.** 20:18–19. Христийн цовдлуулалт дүрслэгдэв, **Мат.** 27:22–50 (Марк 15:22–37; Лук 23:36–46; Иохан 19:17–30). Бурханы Хурганы цовдлуулалтыг Нифай үзэгдэлд харав, **1 Ниф.** 11:33. Христийн зовсныг болон цовдлуулалтын тухай Нифай ярих, **1 Ниф.** 19:9–14. Израилын Ариун Нэгэний тохинуулал хийгээд цовдлуулалтын тухай Иаков ярих, **2 Ниф.** 6:9. Иерусалим дахь Христийн цовдлуулалтын үеэр Америкт их салхи, газар хөдлөлт, түймэр, салхин хүрд үзэгдэх болно, **3 Ниф.** 8. Бибээр цовлогдсон Есүс болой, **С ба Г** 45:51–52. Нас барсан тэдний дундах Христийн тохинуулал түүний цовдлолт хийгээд амилалтын хоорондох хугацаагаар хязгаарлагдсан болой, **С ба Г** 138:27.

ЦУС. Гэтэлгэл, Гэтэлгэх; Есүс Христ; Золиослолыг мөн үз

Эртний израилчууд болон өнөө үеийн олон улс үндэстэн амьдра-

лын үндэс буюу бүх маханбодийн амин чухал эрч хүч хэмээн үздэг. Хуучин Гэрээний үед Их Эзэн цусыг хоол хүнс болгон идэхийг Израилд хориглосон байжээ (Лев. 3:17; 7:26–27; 17:10–14).

Цус нь амьдралд маш чухал хамааралтай учраас цагаатгалын золиослолын хүч нь цусанд байсан ажээ. Хуучин Гэрээний амьтнаар тахил өргөх ёс бол Есүс Христээр хожим нь хийгдсэн агуу золиослолын бэлэгдэл байв (Лев. 17:11; Мосе 5:5–7). Есүс Христийн цагаатгалын цус наманчлагчийг нүглээс ангижруулдаг (1 Иохан 1:7).

Түүний хөлс нь цусны дусал мэт байв, **Лук** 22:44. Христийн цус урсгалтаар бид цэвэршигдсэн билээ, **Евр.** 9:22. Арьсных нь сүв бүрээс цус шүүрсэн, **Моз.** 3:7 (С ба Г 19:18). Их Эзэний цус нүглийн ангижралын тул урссан болой, **С ба Г** 27:2. Есүс өөрийнхөө цус урсгалтаар төгс цагаатгалыг авчирсан болой, **С ба Г** 76:69. Цусаар чи ариусгагдсан бөлгөө, **Мосе** 6:60.

ЦУУРХАЛ. Хилэнцгийг ярих;

Хов живийг мөн үз

Бурхан болон бүх сайн сайхан зүйлсийн эсрэг хүмүүсийг эргүүлэхийн тулд зарим талаар үнэнд тулгуурласан цуурхлууд болон зөрчилдөөнүүдийг Сатан заримдаа тараадаг (Хил. 16:22; ИС—Т 1:1). Есүс Христийн хоёр дахь ирэлтийн нэг тэмдэг бол хүмүүс дайн болон дайны тухай цуурхлуудыг ярих болно (Мат. 24:6; С ба Г 45:26; ИС—Мат. 1:23).

ЦЭВЭР АРИУН, ЦЭВЭР АРИУН

БАЙДАЛ. Ариусгал; Цэвэр, Цэвэр бусыг мөн үз

Нүгэлгүй буюу гэм буруугүй, гэм зэмгүй. Хүний бодол санаа, үйл ажиллагаа бүх талаараа цэвэр ариун байгаа үед тэр цэвэр ариун байдаг. Нүгэл үйлдсэн хүн Есүс Христэд итгэх итгэл, наманчлал хийгээд сайн мэдээний ёслолуудыг хүлээн

авах явдлаар дамжуулан цэвэр ариун болж чадна.

Гар нь цэвэр хийгээд цэвэр ариун зүрхтэй хүн ЭЗЭНий адислалыг хүлээн авах болно, **Дуул.** 24:3–5. ЭЗЭНий савуудыг авч явахуйц цэвэр ариун байгтун та нар, **Иса.** 52:11 (С ба Г 133:4–5). Зүрх сэтгэлдээ цэвэр ариун хүмүүс ерөөлтэй еэ, **Мат.** 5:8 (3 Ниф. 12:8). Хэрэв аливаа зүйлүүд цэвэр ариун байгаа бол, тэдгээр юмсыг бодож санацгаа, **Филип.** 4:8 (ИТ 1:13). Зүрх сэтгэлдээ цэвэр ариун та бүгд тэргүүнээ өргөж, мөн Бурханы таалалт үгийг хүлээн авцгаа, **Иаков** 3:2–3. Та нар ариун зүрх мөн цэвэр гартайгаар Бурхан өөд харж чадах уу? **Алма** 5:19. Тэд Бурханы өмнө цэвэр мөн толбогүй байсан учир жигшлээс өөрөөр нүглийг үзэж эс чадна, **Алма** 13:12. Бүр Христ цэврийн адил, ариусгагдсан бай, **Моро.** 7:48 (Морм. 9:6). Цэвэр ариун хүмүүсийг Христ өөртөө хамгаалан үлдээх болно, **С ба Г** 43:14. Цэвэр ариун хүмүүс Бурханыг үзэх өргөөг Сионд барихыг Их Эзэн зарлиглав, **С ба Г** 97:10–17. Зүрх сэтгэлдээ цэвэр ариун хүмүүс-энэ бол Сион юм, **С ба Г** 97:21.

ЦЭВЭР БА ЦЭВЭР БУС. Бузар,

Бузар бусармаг явдал;
Мосегийн Хууль; Цэвэр ариун,
Цэвэр ариун байдлыг мөн үз

Хуучин Гэрээнд зөвхөн зарим хоол хүнс цэвэрт буюу, өөрөөр хэлбэл, идэхэд тохиромжтойд тооцогддог гэдгийг Их Эзэн Мосед болон эртний израилчуудад илчилсэн байдаг. Израилчуудын цэвэр ба цэвэр бус хоол хүнсний хооронд бий болгосон ялгаа нь тэдний шашны болон нийгмийн амьдралд нэн ихээр нөлөөлжээ. Зарим амьтан, шувууд болон загаснууд нь цэвэр буюу идэхийг зөвшөөрсөн бол бусад нь цэвэр бус бөгөөд хориглогдсонд тооцогддог байв (Лев. 11; Дэд хууль 14:3–20). Зарим өвчтэй хүн мөн цэвэр бусад тооцогддог байв.

Сүнсний утгаараа цэвэр байх гэдэг

нь нүгэлгүй бөгөөд нүгэл үйлдэх хүсэлгүй байх явдал юм. Энэ утгаараа цэвэр үг нь ариун журамтай, ариун зүрхтэй хүнийг дүрслэхэд хэрэглэгддэг (Дуул. 24:4). Бурханы гэрээт хүмүүс үргэлж цэвэр байх онцгой заавартай байдаг (3 Ниф. 20:41; С ба Г 38:42; 133:5).

Цэвэр гартай цэвэр ариун зүрхтэй хүн Их Эзэний уул өөд авирах болно, **Дуул.** 24:3–5. Ямар ч хүнийг бузар, эсвэл цэвэр бус хэмээн бүү нэрлэ, **Үйлс** 10:11–28. Тэр өдөр та нар ариун зүрх мөн цэвэр гартайгаар Бурхан өөд харж чадах уу? **Алма** 5:19. Сионьг цэвэр болох хүртэл Их Эзэн түүнийг ээмлэх болно, **С ба Г** 90:36. Их Эзэний савыг тээхийн тулд та нар цэвэр ариун байгтун, **С ба Г** 133:4–5, 14 (Иса. 52:11).

ЦЭЭЖНИЙ ХУЯГ. Урим ба Туммимыг *мөн үз*

Судруудад хоёр төрлийн цээжний хуягийг өгүүлдэг: (1) Цэргийг хамгаалах хувцасны урд талын хэсэг буюу хуяг. Бэлэгдсэн утгаар бол Гэгээнтнүүд зөв шударгын цээжний хуягийг өөрсдийгөө хилэнцийн эсрэг хамгаалахын тулд өмсөх ёстой (Иса. 59:17; Ефес 6:14). (2) Мосегийн хуулийн дагуу дээд санваартнуудын өмсдөг байсан нэг төрлийн хувцас (Ег 28:13–30; 39:8–21). Үүнийг арванхоёр үнэт чулууг зотон давуун дээр хадаж хийдэг байв. Энэ нь заримдаа Урим ба Туммимтай холбоотой (С ба Г 17:1; ИСТ 1:35; 42, 52).

ЧИДУНЫ МОД. Израил; Тосыг *мөн үз*

Израил болон Библийн нутгуудад нийтлэг байдаг хөдөө аж ахуйн чухал эх сурвалж. Үүнийг мод, жимс, түүнчлэн тосных нь тулд ургуулдаг. Чидуны модыг Израилын угсааны бэлэгдэл болгон судруудад нэн ихээр хэрэглэдэг.

Израилын угсаа бол мөчрүүд нь хугаран тархсан чидуны модтой адилтгам болой, **1 Ниф.** 10:12 (1 Ниф.

15:12). Их Эзэн Израилын угсааг уяхан залуу чидуны модтой зүйрлэжээ, **Иаков** 5–6. Иосеф Смит хэсэг 88 дахь илчлэлтийг чидуны навч хэмээн нэрлэсэн байдаг, **С ба Г** 88-ын толгой гарчиг. Нэгэн сурвалжит хүн жимснийхээ цэцэрлэгт очиж, чидуны арванхоёр мод тарихыг зарц нартаа хэлжээ, **С ба Г** 101:43–62.

ЧИДУНЫ УУЛ. Гетсеманийг *мөн үз*

Иерусалимаас зүүн тийш, Кидроны хөндийн зүүнтэйх толгой. Үүний зүүн бэлийн хөндийд ойрхон Гетсемани Цэцэрлэг байдаг. Бетфейж болон Бетани нь уг толгойн орой дээр болон зүүн бэл дээр байдаг. Энэ уул нь Библийн олон чухал үйл явдал (Мат. 24:3) болсон газар байсан бөгөөд мөн хожмын өдрүүдийн үйл явдлуудад чухал газар байх болно (Зехар. 14:3–5; С ба Г 45:48–54; 133:20).

ЧИХ. Сонсохыг *мөн үз*

Судруудад, чих нь ихэнхдээ Бурханы зүйлсийг ойлгох мөн сонсох чадварын бэлэгдэл болон хэрэглэгддэг.

Тэдэнд чих байвч, сонсох нь үгүй, **Дуул.** 115:6. Их Эзэн чихийг минь сонсохоор сэрээнэ, **Иса.** 50:4–5 (2 Ниф. 7:4–5). Сонсох чихтэй тэр нь сонсог, **Мат.** 11:15. Тэдний чих нь дөнгөж сонсдог, **Мат.** 13:15 (Мосе 6:27). Бурхан өөрийг хайрладаг тэдэнд нүдэнд үзэгдээгүй чихэнд сонсогдоогүй юмсыг бэлтгэсэн, **1 Кор.** 2:9 (С ба Г 76:10). чөтгөр тэдний чихэнд шивнэдэг, **2 Ниф.** 28:22. Та нар сонсож болохын тулд чихээ онгойлго, **Моз.** 2:9 (3 Ниф. 11:5). Би олон удаа дуудуулсан боловч би сонсохоос татгалзсан, **Алма** 10:6. Миний үгст чихээ тавин сонс, **Алма** 36:1 (Алма 38:1; С ба Г 58:1). Сонсохгүй чих гэж үгүй, **С ба Г** 1:2. Даруу байдал болон залбирлаар чих нээгдэх ёстой, **С ба Г** 136:32.

ЧӨЛӨӨЛӨГЧ. Есүс Христийг *мөн үз*

Бүгдийг үхлийн хүлээнснээс, наманчлагчийг нүглийн шийтгэлүүдээс

аварсан учраас Есүс Христ бол хүн төрөлхтний Чөлөөлөгч юм.

Эзэн бол миний хад, миний аврагч, **2 Сам.** 22:2 (Дуул. 18:2; 144:2). Та миний тусламж мөн аврагч, **Дуул.** 40:17 (Дуул. 70:5). Чөлөөлөгч Сионоос гарч ирнэ, **Ром.** 11:26. Гэгээнтнүүд Бурханы Хүүг тэдний Гэтэлгэгч мөн Чөлөөлөгч гэдгийг мэдэх болно, **С ба Г** 138:23.

ЧӨЛӨӨТ ЭЙГӨӨР СОНГОХ

ЭРХ. Сонгох эрхийг үз

ЧӨЛӨӨТ ЭРХ. Боолчлол; Сонгох эрх; Эрх чөлөөт; Эрх чөлөөг мөн үз

Чөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах болон бодож сэтгэх боломжтой байх нөхцөл буюу байдал. Сайн мэдээний зарчмуудад дуулгавартай байх нь нүгэл үйлдэх сүнсний боолчлолоос хүнийг чөлөөтэй байлгадаг (Иохан 8:31–36).

Би чөлөөтэй алхах болно; учир нь би таны дүрэм заавруудыг эрэлхийлдэг, **Дуул.** 119:45. ЭЗЭНий Сүнс байгаа газарт чөлөөт байдал буй, **2 Кор.** 3:17. Христ биднийг чөлөөлсөн эрх чөлөөнд бат зогс, **Гал.** 5:1 (С ба Г 88:86). Чөлөөт байдал болон мөнх амьдралыг сонгоход хүмүүн чөлөөтэй бөлгөө, **2 Ниф.** 2:27. Энэ нутаг чөлөөт байдлын нутаг байх болно, **2 Ниф.** 10:11. Нифайчуудын дундах чөлөөт байдлын жишгийг Моронай бий болгов, **Алма** 46:36. Их Эзэн болон түүний үйлчлэгчид боолчлогдсон сүнснүүдэд чөлөөт байдлыг тунхагладаг, **С ба Г** 138:18, 31, 42.

ЧӨЛӨӨТ, ЭРХ ЧӨЛӨӨ.

Боолчлол; Сонгох эрх; Эрх чөлөөг мөн үз

Албадуулалгүйгээр сонголт хийх хувь хүний эрх чөлөө буюу чадвар. Сүнслэг талаасаа бол, наманчилдаг мөн Бурханы хүсэл зоригийг дуулгавартай дагадаг хүн, Есүс Христийн цагаатгалаар дамжин нүг-

лийн боолчлолоос чөлөөтэй байдаг (Мозая 5:8).

Үнэн чамайг чөлөөтэй болгоно, **Иохан** 8:32. Нүглээс чөлөөтэй болсон хүмүүс мөнх амьдралыг хүлээн авдаг, **Ром.** 6:19–23. Израилын угсааны зөв шударга мөчир боолчлолоос эрх чөлөөнд авчрагдах болно, **2 Ниф.** 3:5. Тэд эрх чөлөөнийхөө төлөө Их Эзэнд хандан залбиран гуйв, **Алма** 43:48–50. Моронай эх орныхоо эрх чөлөөнд баясдаг байв, **Алма** 48:11. Бурханы Сүнс бол эрх чөлөөний сүнс мөн, **Алма** 61:15. Намайг дага, тэгвэл та нар чөлөөт хүмүүс байх болно, **С ба Г** 38:22.

ЧӨТГӨР. Люцифер; Мөхлийн хүүхдүүд; Сүнс—Муу ёрын сүнснүүд; Там; Устгагч; Христийг эсэргүүцэгчийг мөн үз

Сатан. Чөтгөр бол зөв шударгын болон Бурханы хүсэл зоригийг гүйцэлдүүлэхийг эрэлхийлэгчдийн дайсан юм. Тэр нь Бурханы сүнсэн хүү бөгөөд нэгэн цагт Бурханы дэргэд эрх мэдэлтэй тэнгэр элч байсан ажээ (Иса. 14:12; 2 Ниф. 2:17). Хэдий тийм ч, тэрээр мөнх бус амьдралын өмнөх амьдралд бослого гаргаж мөн Эцэгийн сүнсэн хүүхдүүдийн гуравны нэгийг өөртэйгөө хамт бослого гаргахад ятгажээ (С ба Г 29:36; Мосе 4:1–4; Абр. 3:27–28). Тэд тэнгэрээс хөөгдөж, мөнх бус бие махбодийг авч мөнх бус амьдралыг амсах боломжоос татгалзуулагдсан бөгөөд мөнхөд хараагдах болно. Чөтгөр тэнгэрээс хөөгдсөн цагаас тэрээр бүх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг уруу татахыг, бүх хүн төрөлхтнийг өөртэйгөө адил олиггүй болгохын тулд тэднийг Бурханы ажлаас холдуулахыг байнга эрэлхийлдэг (Илч. 12:9; 2 Ниф. 2:27; 9:8–9).

Есүс чөтгөрийг зэмлэв, **Мат.** 17:18. Үүрдийн гал нь чөтгөр болон түүний элчүүдийн тул бэлтгэгдсэн юм, **Мат.** 25:41. Чөтгөрийг эсэргүүц, мөн тэр та нараас зайлна, **Иаков** 4:7. Хилэнцтэн чөтгөрийн боолчлолд доош

аваачигдах болно, **1 Ниф.** 14:7. Чөтгөр бол бүх худал хуурмагийн эцэг, **2 Ниф.** 2:18 (Моце 4:4). Чөтгөр бүх хүмүүнийг өөртэйгөө адил өрөвдэлтэй болгохыг эрэлхийлж байдаг, **2 Ниф.** 2:27. Хэрэв бие махбодь дахин босох ёсгүй бол бидний сүнс чөтгөрийн харьяалалд орох ёстой, **2 Ниф.** 9:8–9. Чөтгөр уурлаж, номхорч, мөн зусардах болно, **2 Ниф.** 28:20–23. Хилэнцэт тэр нь чөтгөрөөс ирэх бөлгөө, **Омнаи** 1:25 (Алма 5:40; Моро. 7:12, 17). Та нарын дунд зөрчлүүд босч ирэхээс, мөн ёсон бусын сүнсийг та нар дагахаас айж болгоомжил, **Моце** 2:32. Хэрэв та нар сайн хоньчны хонь биш бол, чөтгөр та нарын хоньчин байна, **Алма** 5:38–39. Чөтгөр өөрийнхөө хүүхдүүдийг дэмжих нь үгүй, **Алма** 30:60. Чөтгөрийн уруу таталтанд хөтлөгдөхгүйн тулд та нар байнга залбирагтун, **Алма** 34:39 (3 Ниф. 18:15, 18). Чөтгөрийн хүчит салхи та нарын дээр хүчтэй байхгүйн тулд Гэтэлгэгч дээр өөрсдийнхөө суурийг барь, **Хил.** 5:12. Чөтгөр бол бүх нүглийн удирдагч билээ, **Хил.** 6:26–31. Чөтгөр залхай төлөвлөгөөгөө боловсруулахаар завдлаа, **С ба Г** 10:12. Чөтгөр хүмүүний үрсийг уруу татах ёстой нь шаардлагатай ажгуу, эс бөгөөс тэд өөрсөддөө эрх чөлөөтэй байж эс чадна, **С ба Г** 29:39. Адам уруу таталтанд автагдсан учир чөтгөрийн хүсэл зоригт захирагдсан бөлгөө, **С ба Г** 29:40. Мөхлийн хүүхдүүд чөтгөр болон түүний тэнгэр элчүүдтэй хамт мөнхөд хаанчлах болно, **С ба Г** 76:33, 44. Чөтгөр мянган жил хүлэгдэх болно, **С ба Г** 88:110 (Илч. 20:2). Хилэнцэт нэгэн гэрэл болон үнэнийг холдуулан аваачдаг, **С ба Г** 93:39. Сатан түүний эхний түвшинг сахисангүй, **Абр.** 3:28.

Чөтгөрийн сүм: Бурханы Хурганы эсрэг тэмцдэг, цэвэр бөгөөд төгс сайн мэдээг гуйвуулдаг газар дэлхий дээрх хилэнцэт хийгээд дэлхийн байгууллага болгон.

Чөтгөр агуу хийгээд жигшүүрт

сүмийг үүсгэв, **1 Ниф.** 13:6 (1 Ниф. 14:9). Бурханы Хургын болон чөтгөрийн гэсэн зөвхөн хоёрхон сүм байдаг. **1 Ниф.** 14:10 (Алма 5:39). Чөтгөрийн сүмээс бусад ямар ч сүмийн эсрэг бүү тэмц, **С ба Г** 18:20. Агуу хийгээд жигшүүрт сүм нь доош хаягдах болно, **С ба Г** 29:21.

ЧУУЛГА. Санваарыг мөн үз

Чуулга гэдэг үг хоёр утгаар хэрэглэгдэж болно: (1) Санваарын адил албан тушаал бүхий эрэгтэйчүүдийн бүлэг. (2) Сүмийн ажил хэргийг явуулах цуглаанд оролцох ёстой гишүүдийн дийлэнх олонх буюу эсвэл хамгийн цөөн нь (С ба Г 107:28).

Тэргүүн Зөвлөлийн, Арванхоёрын болон Далын түүнчлэн тэдгээрийн өөр хоорондын харилцааны чуулгууд дүрслэгдэв, **С ба Г** 107:22–26, 33–34 (С ба Г 124:126–128). Эдгээр чуулгуудын шийдвэрүүд санал нэгдмэл байх ёстой, **С ба Г** 107:27. Чуулгын шийдвэрүүд бүхий л зөв шударга байдалд гардаг байх ёстой, **С ба Г** 107:30–32. Санваартны чуулгуудын ерөнхийлөгчдийн үүргүүд дүрслэгдэв, **С ба Г** 107:85–96. Үйл ажиллагаа явуулагч тохинуулагчдад зориулан ахлагчдын чуулга эмхлэгдэн бий болов, **С ба Г** 124:137.

ШАВЬ. Буулга; Төлөөлөгч;

Хөрвүүлэг, Хөрвөгч;

Христийнхнийг мөн үз

Христийн сургаалуудын дагуу амьдардаг Есүс Христийн дагалдагч (С ба Г 41:5). Мөнх бус номлолынхоо үед Христийн дуудсан Арванхоёрыг дүрслэхэд шавь гэдэг үгийг хэрэглэсэн байдаг (Мат. 10:1–4). Шавь нь мөн нифайчууд болон леменчүүд дунд байсан түүний Сүмийг удирдахаар Есүсийн сонгосон арван хоёр хүнийг дүрслэхэд хэрэглэгдсэн байдаг (3 Ниф. 19:4).

Миний дагалдагчдын дунд хуулийг битүүмжил, **Иса.** 8:16. Хэрэв чи миний үгэнд үргэлжлүүлбэл, тэгээд чи

миний дагалдагч мөн, **Иохан** 8:31. Мормон Есүс Христийн шавь байв, **3 Ниф.** 5:12–13. Та нар миний шавь нар, **3 Ниф.** 15:12. Гурван шавь үхлийг амсахгүй байх болно, **3 Ниф.** 28:4–10. Сэрэмжлүүлгийн дуу хоолой миний шавь нараас байх болно, **С ба Г** 1:4. Миний шавь нар ариун газарт зогсох болно, **С ба Г** 45:32. Ядуус хийгээд гачигдагсад, өвчтөнүүд хийгээд зовж шаналагсдыг санадаггүй тэд миний шавь нар биш болой, **С ба Г** 52:40. Өөрийнхөө амьдралыг өгөхөд бэлэн биш тэр нь миний шавь биш, **С ба Г** 103:27–28.

ШАДРАХ. Даниелыг мөн үз

Хуучин Гэрээнд, Шадрах, Мешах Абед-него нар бол Вавилоны хаан Небухаднезарын ордонд авчрагдсан гурван залуу израил байв. Шадрахын еврей нэр нь Ханания байжээ. Дөрвөн залуу эр хааны амттан шимтгэн болон дарснаас хүртэж биеэ бузарлахгүй хэмээн эсэргүүцэв, (Дан. 1). Шадрах, Мешах, Абед-него нарыг хаан шатаж буй галд хаясан бөгөөд Бурханы Хүүгээр аврагджээ (Дан 3).

ШАСТИРУУД

Хуучин Гэрээний хоёр ном. Тэдгээр нь Бүтээлтээс эхлэн иудейчүүдийг Иерусалимд буцаж ирэхийг зөвшөөрсөн Корешийн тунхаглалыг хүртэлх үйл явдлуудын богино түүх юм.

Шастирын Дээд: Бүлэг 1–9-р нь Адамаас Саулыг хүртэлх уг гарлыг жагсаан тоочдог. Бүлэг 10 нь Саулын үхлийг цэдэглэжээ. Бүлэг 11–22 нь Давидын хаанчлалтай холбоотой үйл явдлын цэдэг юм. Бүлэг 23–27-д Соломон хаан болсон хийгээд левичүүд зохион байгуулагдсаныг тайлбарладаг. Бүлэг 28-д Давид ариун сүм барихыг Соломонд зарлигласныг тайлбарладаг. Бүлэг 29-д Давидын үхлийг цэдэглэжээ.

Шастирын Дэд: Бүлэг 1–9-д Соломоны хаанчлалтай холбоотой үйл явд-

луудыг бичсэн байдаг. Бүлэг 10–12 нь Израилын Нэгдсэн Хаант Улс өмнөд болон умард хаант улсуудад хуваагдсан үе дэх Соломоны хүү Рехобоамын хаанчлалын тухай өгүүлдэг. Бүлэг 13–36 нь Иудагийн хаант улс Небухаднезарт боолчлогдох хүртэлх хэд хэдэн өөр хаадын хаанчлалыг дүрсэлжээ. Иудейн боолчлогдсон хүүхдүүд Иерусалимд буцаж ирж болно гэсэн Корешийн тогтоолоор ном төгсдөг.

ШАШНЫ ЦУГЛАРАЛТ. Ариун ёслолыг үз

ШЕМ. Ноа, Библийн патриархыг мөн үз

Хуучин Гэрээнд, Ноагийн шударга хүү, мөн ам дамжсан яриагаар бол Шемит буюу Семитийн хүмүүс болох араб, еврей, вавилоныхан, сиричүүд, фойникчүүд болон ассиричуудын өвөг дээдэс (Эхл. 5:29–32; 6:10; 7:13; 9:26; 10:21–32; Моисе 8:12). Хожмын үеийн илчлэлтэд Шемийг “агуу дээд санваартан” байсан хэмээн өгүүлдэг (С ба Г 138:41).

ШЕРИМ. Христийг эсэргүүцэгчийг мөн үз

Христийг үгүйсгэж мөн тэмдэг шаардсан Мормоны Номон дахь нэг хүн (Иаков 7:1–20).

ШИБЛОН. Алмагийн хүү Алмаг мөн үз

Мормоны Номонд Залуу Алмагийн хүү. Шиблон зорамчуудад сайн мэдээг зааж байсан бөгөөд зөв шударгынхаа улмаас хавчигдаж байв. Итгэлтэй хийгээд тэвчээртэй байсан учраас Их Эзэн түүнийг хавчлагаас чөлөөлжээ (Алма 38). Шиблон тэрчлэн нифайчуудын цэдгийг хэсэг хугацаанд анхаарал тавин хамгаалж байв (Алма 63:1–2, 11–13).

ШИЗ. Жаредчуудыг мөн үз

Мормоны Номон дахь жаредчуудын цэргийн жанжин. Тэрээр жаред

үндэстэн устгагдсан их дайны төгсгөлд нас баржээ (Ифер 14:17–15:31).

ШИНЭ БА ҮҮРДИЙН ГЭРЭЭ.

Гэрээг мөн үз

Есүс Христийн бүрэн сайн мэдээ (С ба Г 66:2). Энэ бол урвалтын үеийн дараа шинээр илчлэгдсэн шинэ үе болгон юм. Энэ нь Бурханы гэрээ бөгөөд сайн мэдээний эрин үе болгонд хүмүүс үүнийг хүлээн авч мөн баяр баяслыг эдлэхэд бэлэн байдаг гэсэн утгаараа үүрдийнх юм. Шинэ ба үүрдийн гэрээг Есүс Христ бошиглогч Иосеф Смитээр дамжуулан дэлхий дээр хүмүүнд дахин илчилсэн билээ. Энэ нь хүмүүний аврал, үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хангадаг баптисм болон ариун сүмийн гэрлэлт зэрэг санваарын эрх мэдлээр гүйцэтгэгддэг ариун нандин ёслолуудыг агуулдаг. Хүмүүс сайн мэдээг хүлээн зөвшөөрч түүнчлэн Бурханы зарлигуудыг сахихаар амлахад, Бурхан өөрийн шинэ ба үүрдийн гэрээний адислалуудыг тэдэнд өгөхөөр гэрээ байгуулдаг.

Би өөрийн гэрээг чи бид хоёрын хооронд байгуулна, **Эхл.** 17:7. Тэрээр үүрдийн санваарын гэрээг авах болно, **Тоол.** 25:13. Хүмүүн ёслолуудыг өөрчилж, үүрдийн гэрээг зөрчжээ, **Иса.** 24:5 (С ба Г 1:15). Би та нартай мөнхийн гэрээ байгуулна, **Иса.** 55:3 (Иер. 32:40). Энэ нь үүрдийн гэрээ байх болно, **Езек.** 37:26. Их Эзэн шинэ гэрээ хийж, тэгээд хуучин нь байхгүй болов, **Евр.** 8:13. Есүс бол шинэ гэрээний зууч мөн, **Евр.** 12:24 (С ба Г 76:69). Энэ бол шинэ ба үүрдийн гэрээ мөн, **С ба Г** 22:1. Би өөрийн үүрдийн гэрээг дэлхийд илгээлээ, **С ба Г** 45:9 (С ба Г 49:9). Их Эзэн сайн мэдээний байдлыг, өөрийн үүрдийн гэрээг илгээв, **С ба Г** 66:2 (С ба Г 133:57). Селестиел хаант улсад хамгийн дээд зэрэглэлийг олж авахын тулд хүн гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээнд орох ёстой, **С ба Г** 131:1–2. Шинэ ба үүрдийн гэрээ нь Их Эзэний алдар

суугийн бүрэн байдлын төлөө үндэслэгдсэн ажгуу, **С ба Г** 132:6, 19.

ШИНЭ ГЭРЭЭ. Библи;

Судруудыг мөн үз

Есүс Христ, Төлөөлөгчид болон Есүс Христийн бусад дагалдагчдын амьдрал хийгээд тохинууллын талаар сүнсээр нөлөөлөгдсөн (эх нь грек хэл дээр) бичээсүүдийн цуглуулга. Шинэ Гэрээ нь ерөнхийдөө Сайн мэдээнүүд, Төлөөлөгчдийн үйлс, Паулын захидлууд, нийтлэг захидлууд, тэрчлэн Илчлэлтийн ном гэсэн хэсгүүдэд хуваагддаг.

Дөрвөн Сайн мэдээ — Матай, Марк, Лук болон Иоханы номнууд бол Христийн амьдралын тухай шастирууд юм. Үйлсийн ном нь Сүмийн болон Төлөөлөгчдийн түүхийг, ялангуяа Христийн нас эцэслэсний дараах Паулын номлолын аяллуудыг өгүүлдэг. Паулын захидлууд нь Сүмийн удирдагчид хийгээд гишүүдэд заавар өгсөн байдаг. Бусад захидлуудыг бусад Төлөөлөгчид бичсэн бөгөөд анхны Гэгээнтнүүдэд нэмэлт зөвлөгөө өгсөн байдаг. Төлөөлөгч Иоханы бичсэн Илчлэлт ном нь ихэвчлэн эцсийн өдрүүдэд хамаарах бошиглалуудыг агуулжээ.

ШИНЭ ИЕРУСАЛИМ

Гэгээнтнүүд цугларч мөн Их Эзэн өөрийн биеэр тэдний хамт Мянган жилийн турш хаанчлан суух тэр газар. Сион (Шинэ Иерусалем) Америк тивд баригдах болно, мөн дэлхий шинэчлэгдэж диваажингийн алдар суугаа олно, (ИТ 1:10). Энэ нь Мянган жилийн эхэнд тэнгэрээс доош бууж ирэх ариун хотод хамаардаг.

Сионоос хууль гарах болно, **Мика** 4:2. Бурханы маань хотын нэр нь Шинэ Иерусалем, **Илч.** 3:12. Иохан тэр ариун хот, Шинэ Иерусалемыг үзжээ, **Илч.** 21:1–5. Би энэ хотыг энэ нутагт тогтнуулах болно, мөн энэ нь Шинэ Иерусалем байх болно, **3 Ниф.** 20:22. Шинэ Иерусалим

Америкт баригдах болно, **Ифер** 13:3–6, 10. Шинэ Иерусалим хот бэлтгэгдэх болно, **С ба Г** 42:9, 35, 62–69. Гэгээнтнүүд цугларч мөн Шинэ Иерусалемыг барих ёстой, **С ба Г** 45:63–75. Шинэ Иерусалим Миссурид баригдах ёстой, **С ба Г** 84:1–5 (С ба Г 57:1–3). Хурга Сионы Уулан дээр, мөн ариун хот, Шинэ Иерусалем дээр зогсох болно, **С ба Г** 133:56. Миний асар Сион, Шинэ Иерусалем хэмээн нэрлэгдэх болно, **Моце** 7:62.

ШОДОЛТ

Хэд хэдэн хувилбараас нэгийг нь, ихэвчлэн нилээд хэдэн зурвас цаас буюу модны өөдөснөөс нэгийг нь сугалах буюу сонгох арга. Үүнийг сугалах буюу шодох гэдэг.

Тэд шодон хувцсыг нь хувааж авав, **Мат.** 27:35 (Дуул. 22:18; Марк 15:24; Лук 23:34; Иохан 19:24). Тэд шодож, мөн шодолт нь Маттиа дээр ноогдов, **Үйлс** 1:23–26. Бид шавга орхин хэн нь Лебений гэрт орвол зохиыхыг шодов, **1 Ниф.** 3:11.

ШУДАРГА ЁС. Нигүүлсэл, Нигүүлсэнгүй; Цагаатгал, Цагаатгахыг мөн үз

Зөв шударга бодол санаа хийгээд үйл хэргүүдийн үр дагавар болж ямагт ирдэг адислалууд, түүнчлэн наманчлаагүй нүглийн төлөөх шийтгэл. Шударга ёс нь Бурханы хууль зөрчигдсөн тухай бүрд шийтгэлийг шаарддаг мөнхийн хууль юм (Алма 42:13–24). Хэрэв нүгэл үйлдэгч наманчилдаггүй бол тэр шийтгэл хүлээх ёстой (Моз. 2:38–39; С ба Г 19:17). Хэрэв тэр наманчилдаг бол, Аврагч Цагаатгалаар дамжуулан шийтгэлийг төлж, нигүүлсэл үзүүлдэг (Алма 34:16).

Нүгэл үйлдэгч бодгаль үхэх болно, **Езек.** 18:4. Шударгыг үйлд гэхээс өөр юуг ЭЗЭН чамаас шаарддаг билээ? **Мика** 6:8. Есүс шударга байж бидний нүглийг өршөөх болно, **1 Иохан** 1:9. Бурханы шударга ёс

нь ёс бусыг үйлдэгсдийг зөв шударгыг үйлдэгсдээс зааглан хуваасан билээ, **1 Ниф.** 15:30. Түүний шударга ёсны шаардлагуудыг Цагаатгал хангадаг бөлгөө, **2 Ниф.** 9:26. Бүх хүн төрөлхтөн унасан, мөн шударга ёсны хяналтад байдаг билээ, **Алма** 42:14. Цагаатгал нь шударга ёсны шаардлагаар бий болсон юм, **Алма** 42:15. Нигүүлсэл нь шударга ёсыг дээрэмдэж болно хэмээн бодно уу, чи? **Алма** 42:25. Та нар эс наманчлах аваас Бурханы шударга ёс та нарын дээр дүүлжээстэй байдаг, **Алма** 54:6. Шударга ёс хийгээд шүүлт нь миний хуулинд орсон шийтгэл болой, **С ба Г** 82:4. Шударга ёс өөрийнхөө замыг үргэлжлүүлж мөн өөрийнхөөсөө шаарддаг, **С ба Г** 88:40. Бурханы шударга ёс хийгээд хуулиудаас хэн ч чөлөөлөгдөх нь үгүй, **С ба Г** 107:84.

ШУДАРГА, ШУДАРГА ЗАН ЧАНАР. Шударга зарчимч байдлыг мөн үз

Чин үнэнч сэтгэлтэй, хууран мэхэлдэггүй байх.

Итгэлтэйгээр үйлдэгчид Эзэний таалалд нийцдэг, **Сур.** үгс 12:22. Амласан зүйлээ биелүүлж бай, **Номл.** үг 5:4–5. Бид шударга бус явдлын нуугдмал зүйлээс татгалзсан билээ, **2 Кор.** 4:1–2. Шударга яриатай бай, **1 Петр** 2:12. Худалчид халаг, учир нь тэрээр доош тамд хаягдах болно, **2 Ниф.** 9:34. Сүнс үнэнийг хэлдэг мөн хуурах нь үгүй, **Иаков** 4:13. Хөршөөсөө зээлсэн хэн боловч, зээлсэн тэр зүйлээ эргүүлж өгөх ёстой, **Моз.** 4:28 (С ба Г 136:25). Шударгаар харьцах, зөвөөр шүүх, мөн сайныг үйлдэхээ мэдэгтүн, **Алма** 41:14. Хүн бүр шударгаар үйлдэг, **С ба Г** 51:9. Зүрх сэтгэлээ мэддэг тэд бүгд шударга бөгөөд надаас хүлээн зөвшөөрөгддөг, **С ба Г** 97:8. Шударга, ухаалаг хийгээд сайн хүмүүс улс төрийн албан тушаалуудын тул эрэлхийлэгдэх ёстой, **С ба Г** 98:4–10. Хөршийнхөө хаясан зүйлийг эргүүлж өгөхийн тулд хичээнгүйлэн

эрж хай, **С ба Г** 136:26. Шударга байхад бид итгэдэг, **ИТ** 1:13.

ШУНАЛТ ХҮСЭЛ ТАЧААЛ.

Тачаангуй; Хүсэл таашаалыг мөн үз

Ямар нэг юманд зохисгүйгээр ихэд хүсэн шунах.

Тэр эмийн гоо үзэсгэлэнг зүрхэндээ бүү хүс, **Сур. үгс** 6:25. Эмэгтэй хүнийг тачаадан хардаг хүн бүр садар самууныг аль хэдийнээ үйлдсэн байдаг, **Мат.** 5:28 (3 **Ниф.** 12:28). Эрчүүд бие биендээ тэмүүлэх хүсэлд шатжээ, **Ром** 1:27. Тэд өөрсдийн хүслийн дагуу өөрсөдлөө багш нарыг бөөгнөрүүлэх болно, **2 Тим.** 4:3–4. Лебен бидний эдийг үзээд, үүнд шунав, **1 Ниф.** 3:25. Нүднийхээ тачаал шуналын төлөө дахин бүү яв, **Алма** 39:3–4, 9. Эмэгтэй хүнийг тачаангуйгаар хардаг тэрээр итгэлийг үгүйсгэдэг, **С ба Г** 42:23. Өөрсдийн бүхий л шунаг хүслүүдээс татгалзагтун, **С ба Г** 88:121.

ШУНАЛ, ШУНАХ ШУНАХАЙ-

РАХ. Атаархахыг мөн үз

Шунах гэдэг нь хэн нэгэнд атаархах буюу ямар нэг зүйлтэй байх хэт их хүсэл гэж судруудад хэрэглэгддэг.

Бүү шунахайр, **Ег.** 20:17 (Дэд хууль 5:21; **Моз** 13:24; **С ба Г** 19:25). Шударга бусаар олсныг үзэн яддаг хүний өдөр хоног уртасна, **Сур. үгс** 28:16. Тэд талбайнуудад шунахайрч тэднийг авдаг, **Мика** 2:2. Шуналаас болгоомжил, **Лук** 12:15. Хуульд бүү шунахайр хэмээн хэлжээ, **Ром** 7:7. Хожмын өдрүүдэд хүн шунахай болно, **2 Тим.** 3:1–2. Лебен бидний эдийг үзээд, тэрээр тэдгээрт шунасан бөлгөө, **1 Ниф.** 3:25. Чи өөрийнхөө эд хөрөнгөнд харамч шунаг байх ёсгүй, **С ба Г** 19:26. Шунахай байхаа зогс, **С ба Г** 88:123. Өөрийнхөө ахын юманд бүү шуна, **С ба Г** 136:20.

ШҮҮГЧ, ШҮҮЛТ.

Есүс Христ— Шүүгч; Зэмлэл, Зэмлэх; Эцсийн шүүлтийг мөн үз

Сайн мэдээний зарчмуудад ний-

цүүлэн хүний зан байдалд үнэлэлт дүгнэлт өгөх; шийдвэр гаргах; хилэнцэт муугаас сайныг ялгах.

Мосе хүмүүсийг шүүхээр суув, **Ег.** 18:13. Зөв шударга байдалд чи хөршийгөө шүүх болно, **Лев.** 19:15. Чи шүүгдэхгүйн тулд бүү шүү, **Мат.** 7:1 (ИСО, **Мат.** 7:1–2; **Лук** 6:37; **3 Ниф.** 14:1). Хуулинд нүгэл үйлдсэн болгон нь уг хуулиар шүүгдэх ёстой, **Ром** 2:12. Гэгээнтнүүд дэлхийг шүүх болно, **1 Кор.** 6:2–3. Үүрдийн Бурханы Хүү дэлхийгээр шүүгдсэн байв, **1 Ниф.** 11:32. Хурганы Арванхоёр Төлөөлөгч Израилын арван хоёр овгийг шүүх болно, **1 Ниф.** 12:9 (**С ба Г** 29:12). Үхэл, там мөн чөтгөр бас түүгээр шүүрэгдсэн бүгд шүүгдэх ёстой, **2 Ниф.** 28:23 (1 **Ниф.** 15:33). Чамд хандан хөрөнгөнөөс чинь гуйх тэр хүнийг та нар шүүж, мөн буруутгах аваас, эд хөрөнгөө харамласны учир та нарт ирэх зэмлэл хичнээн илүү их байх билээ, **Моз.** 4:22. Хүмүүн өөрсдийн үйлүүдийн дагуу шүүгдэх болно, **Алма** 41:3. Зөв шударгаар шүү, тэгвээс шударга ёс чамд буцаж сэргээгдэх болно, **Алма** 41:14. Бичигдсэн байх ёстой тэр номноос дэлхий шүүгдэх болно, **3 Ниф.** 27:23–26 (Илч. 20:12). Энэ хүмүүсийн үлдэгдэл нь энэ нутагт Есүсийн сонгосон арванхоёроор шүүгдэх болно, **Морм.** 3:18–20. Хилэнцтээс сайныг ялган шүүх арга замыг Мормон тайлбарлав, **Моро.** 7:14–18. Зөв шударгаар шүүхэд хөтөлдөг Сүнсэнд итгэлээ тавигтун, **С ба Г** 11:12. Чи бид хоёрын хооронд Бурхан шүүгч хэмээн та нар зүрх сэтгэлдээ эзлэх учиртай, **С ба Г** 64:11. Их Эзэний Сүм үндэстнүүдийг шүүх болно, **С ба Г** 64:37–38. Махан бодь дахь хүмүүний дагуу шүүгдэж болохын тулд Хүү шорон дахь сүнснүүдэд айлчлан очив, **С ба Г** 76:73 (1 **Петр** 4:6) Бишоп нь ерөнхий шүүгч байх болно, **С ба Г** 107:72–74. Их Эзэн бүх хүмүүнийг тэдний ажлуудын дагуу, зүрх сэтгэлийнх нь хүслийн дагуу шүүх болно, **С ба Г** 137:9.

ШҮҮГЧДИЙН НОМ

Хуучин Гэрээний нэг ном. Шүүгчдийн ном нь Иошуаг нас барснаас Самуелыг төрөх хүртэлх израилчуудын тухай өгүүлдэг.

Бүлэг 1–3 нь Шүүгчдийн бүхэл номны өмнөх үг юм. Эдгээр нь израилчууд дайснуудаа хөөгөөгүй учир (Шүүгч. 1:16–35) үр дагавруудыг итгэлээ алдах, үл итгэгчидтэй гэрлэх болон хиймэл шүтээн бишрэн шүтэх явдлыг амсах ёстойг тайлбарладаг. Бүлэг 3–5 нь Израилыг канаанчуудаас чөлөөлсөн Дебора, Барак нарын үзэж туулсан зүйлүүдийг өгүүлдэг. Бүлэг 6–8 нь Израилыг миданчуудаас чөлөөлөхөд Их Эзэн адисалсан, итгэлийг хөхиүлэн дэмжигч Гидеоны туршлагауд юм. Бүлэг 9–12-т нилээд хэдэн өөр эрчүүд ихэвчлэн урвалт хийгээд дарлал доромжлол дор Израилын шүүгчээр үйлчилдэг. Бүлэг 13–16 нь сүүлчийн шүүгч Самсоны мандалт хийгээд уналтын тухай өгүүлдэг. Сүүлчийн бүлгүүд 17–21 нь Израилын гүнзгий нүглийг илчилсэн хавсралт болгон дүрсэлдэг.

ШҮҮЛТ, ЭЦСИЙН. Буруутгал,

Буруутгах, Есүс Христ —
Шүүгч; Шүүлт, Эцсийн
шүүлтийг мөн үз

Амлуулалтын дараа тохиох эцсийн шүүлт. Бидний хүлээн авах мөнхийн алдар сууг тодорхойлохын тулд Бурхан Есүс Христээр дамжуулан хүн бүрийг шүүх болно. Энэхүү шүүлт нь хүн бүр Бурханы зарлигуудад дуулгавартай байх түүний дотор Есүс Христийн цагаатгагч золиослолыг хүлээн зөвшөөрөх явдал дээр үндэслэгдэх болно.

Эцэг бүх шүүлтийг Хүүд даатгасан билээ, **Иохан** 5:22. Бид бүгдээрээ Бурханы шүүлтийн сэнтийний өмнө зогсох болно, **Ром** 14:10. Нас барагсад бичигдсэн зүйлүүдээр шүүгдэж байв, **Илч.** 20:12 (С ба Г 128:6–7). Өөрийн бүхий л үйлийнхээ тул чи

шүүлтэнд хүргэгдэх болно, **1 Ниф.** 10:20. Арванхоёр Төлөөлөгч мөн Нифайн арванхоёр шавь Израилыг шүүх болно, **1 Ниф.** 12:9 (С ба Г 29:12). Ариун Нэгэний шүүлтийн суудлын өмнө бүгдээрээ очих ёстой, **2 Ниф.** 9:15. Тэрхүү дуурсгалт өдөрт та нар өөрсдийн бодгалиудыг бэлтгэгтүн, **2 Ниф.** 9:46. Та нар өөрсдийгөө Бурханы индрийн өмнө байгаагаар төсөөлж чадна гэж үү? **Алма** 5:17–25. Есүс Христ дэлхийг шүүхээр зогсох болно, **3 Ниф.** 27:16. Бурханлиг бусчууд дээрх шүүлтэд Их Эзэн зүхэлтэйгээр доош бууж ирэх болно, **С ба Г** 133:2.

ЭВ НЭГДЭЛ. Бурхан, Бурхан

Тэргүүтнийг мөн үз

Бодол, хүсэл, зорилгоороо юуны өмнө Тэнгэрлэг Эцэгт болон Есүс Христ тэгээд дараа нь бусад Гэгээнтнүүдтэй нэг болох.

Ах дүүсийн хувьд нэгдмэлээр амьдрах нь сайхан, **Дуул.** 133:1. Би, миний Эцэг хоёр нэг юм, **Иохан** 10:30 (С ба Г 50:43). Есүс болон түүний Эцэг нэгийн адил бүгд нэг байгаасай хэмээн Есүс залбирав, **Иохан** 17:11–23 (3 Ниф. 19:23). Та нар хоорондоо хаягал гаргахгүй, харин хоорондоо нягт нэгдэхийг би хүсч байна, **1 Кор.** 1:10. Бүх зүйлүүдэд нэгдэн хамтарч хатуу шийдэмгий нэг бодол мөн нэг сэтгэлтэй бай, **2 Ниф.** 1:21. Гэгээнтнүүд зүрх сэтгэлээ хамтдаа нэгтгэх ёстой, **Моз.** 18:21. Нифай шавь нар нь нэгдмэл байхын төлөө Есүс залбирчээ, **3 Ниф.** 19:23. Шавь нар агуу залбирал хийгээд мацаг барилтад нэгджээ, **3 Ниф.** 27:1. Эцэг, Хүү, Ариун Сүнс нэг юм, **С ба Г** 20:27–28 (С ба Г 35:2; 50:43). Үнэн Сүмд нэгдэх нь чиний үүрэг, **С ба Г** 23:7. Залбиралд нэгдэн, итгэлээр юуг ч асуулаа гэсэн чи хүлээн авах болно, **С ба Г** 29:6. Хэрэв та нар нэг биш бол та нар миний биш, **С ба Г** 38:27. Их Эзэн хүмүүсээ нэг зүрх сэтгэл хийгээд нэг оюун ухаантай байсан учир Сион хэмээн нэрлэсэн бөлгөө, **Мосе** 7:18.

ЭГЧ. Ах нар, Ах; Хүн, Хүмүүн,
Хүмүүсийг *мөн үз*

Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд болохын хувьд бүх эрэгтэй эмэгтэй хүмүүс сүнслэг ах эгч дүүс юм. Сүмд, Сүмийн эмэгтэй гишүүд хийгээд найзууд ихэнхдээ эгч хэмээн дуудагддаг.

Миний Эцэгийн тааллыг хэрэгжүүлдэг тэд миний ах эгчтэй адил юм, **Мат.** 12:50 (Марк 3:35). Сүм дэх ах эгч нарын хооронд нүглээ нанманчлахыг зохицуулах хууль бий болов, **С ба Г** 42:88–93.

ЭГЭЛ ХҮН. Адам Ева хоёрын уналт; Бурханаас төрсөн; Дахин төрсөн; Зуурдыныг *мөн үз*

Ариун Сүнсний удирдамжаар биш, харин маханбодийн хүсэл эрмэлзэл хийгээд дур таашаал, мэдрэмжээр нөлөөлөгдөхөөр сонгодог хүн. Ийм хүн сүнсний зүйлүүдийг биш, харин биет зүйлүүдийг ойлгож чаддаг. Бүх хүмүүс Адам Ева хоёрын уналтын улмаас шунаг сэтгэлтэй буюу мөнх бус болсон байна. Хүн болгон Есүс Христийн цагаатгалаар дамжин эгэл хүн байхаа больж дахин төрөх ёстой.

Эгэл хүн Сүнсний зүйлүүдийг хүлээн авдаггүй, **1 Кор.** 2:14. Эгэл хүн бол Бурханы дайсан бөгөөд хойш тавигдах ёстой **Моз.** 3:19. Эгэл чанартаа эсэргүүцдэг тэрээр унасан байдалдаа хэвээр үлддэг **Моз.** 16:15 (Алма 42:7–24; С ба Г 20:20). Эдгээр зүйлүүдийг мэддэг ямар эгэл хүн байдаг билээ? **Алма** 26:19–22. Эгэл буюу төрөлхийн хүмүүс дэлхийд Бурхангүй байдаг, **Алма** 41:11. Өөрийн зөрчлийн улмаас хүн сүнсний хувьд үхмэл болсон юм, **С ба Г** 29:41. Ямар ч эгэл хүн Бурханы дэргэд оршиж чадах нь үгүй бөлгөө, **С ба Г** 67:12. Мөн хүмүүн шунаг, тачаангуй хийгээд чөтгөрийн санаатай болж эхлэв, **Мосе** 5:13 (Мосе 6:49).

ЭД БАЯЛАГ. Баялгуудыг үз

ЭДГЭЭЛТ, ЭДГЭЭХ. Өвчтөнийг адислах; Тослохыг *мөн үз*

Бие болон сүнслэг байдлын аль алинаар нь дахин сайн буюу эрүүл болгох. Их Эзэн хийгээд түүний үйлчлэгчид гайхамшигтайгаар эдгээсэн олон жишээг судрууд агуулдаг.

Эзэн би бол та нарыг эдгээгч билээ, **Ег.** 15:26. Нааман Иордан голд биеэ долоон удаа угааж, эдгэрэв, **Хаад.** дэд 5:1–14. Түүний шархаар бид эдгэрсэн, **Иса.** 53:5 (Моз. 14:3). Зөв шударгын жигүүртээ эдгээлттэйгээр мандах болно, **Малах.** 4:2. Есүс алив төрлийн өвчин эмгэгийг эдгээж байлаа, **Мат.** 4:23 (Мат. 9:35). Тэрээр бүх төрлийн өвчин эмгэгийг эдгээх хүчийг тэдэнд өгчээ, **Мат.** 10:1. Зүрх сэтгэл нь эмтэрсэн тэднийг эдгээхээр тэрээр намайг илгээсэн, **Лук** 4:18. Тэд Бурханы Хурганы хүчээр эдгээгдэж байв, **1 Ниф.** 11:31. Хэрэв та Христийн гэтэлгэлд итгэдэг бол та эдгээгдэж чадна, **Алма** 15:8. Тэрээр тэднийг нэг бүрчлэн эдгээв, **3 Ниф.** 17:9. Надад эдгэрэх итгэлтэй тэр нь эдгэрэх болно, **С ба Г** 42:48. Тэд миний нэрээр өвчтөнийг эдгээх болно, **С ба Г** 84:68. Эдгээх бэлэгт бид итгэдэг, **ИТ.** 1:7.

ЭММАНУЕЛ. Иммануэлыг үз

ЭМЭГТЭЙ ХҮН, ЭМЭГТЭЙЧҮҮД.

Хүмүүн, Хүмүүс; Эрэгтэй хүн,
Эрэгтэйчүүдийг *мөн үз*

Насанд хүрсэн эмэгтэй хүн, Бурханы охин. *Эмэгтэй* гэсэн нэр нь сурдарт заримдаа хүндэтгэлийн нэр болон ашиглагддаг (Иохан 19:26; Алма 19:10).

Бурхан эрэгтэй болон эмэгтэйг бүтээв, **Эхл.** 1:27 (Мосе 2:27; 6:9; Абр. 4:27). Ариун журамт эмэгтэй эрдэнэсээс ч үнэтэй, **Сур.** үгс 31:10–31. Эмэгтэй хүн эрэгтэй хүний алдар юм, **1 Кор.** 11:7. Эзэн дотор эр хүнгүйгээр эмэгтэй хүн гэж үгүй бөгөөд эмэгтэй хүнгүйгээр эрэгтэй хүн гэж үгүй юм, **1 Кор.** 11:11. Эмэгтэй хүн

даруу түвшин байдлаар өөрийгөө чимэх ёстой, **1 Тим.** 2:9–10. Их Эзэн бибээр эмэгтэйчүүдийн ариун явдалд баясдаг билээ, **Иаков** 2:28. Нүглүүд чинь чамд өршөөгдөх болно, мөн чибээр сонгогдсон эмэгтэй болой, **С ба Г** 25. Эмэгтэйчүүд тэтгүүлэхийн тулд нөхрөөсөө нэхэх эрхтэй, **С ба Г** 83:2.

ЭМЭЭХ. Бишрэл хндэтгэл; Зориг, Зоригтой; Итгэлийг *мөн үз*

Эмээх нь хоёр утгатай байж болно: (1) Бурханаас эмээх нь түүнийг дээдлэн хүндэлж, бишрэн, зарлигуудыг нь дуулгавартай дагах мэдрэмжийг төрүүлдэг; (2) хүнээс, үхэх аюулаас, өвчин шаналал хийгээд хилэнц мэтийн зүйлүүдээс айж, эмээх явдал мөн.

Бурханаас эмээх нь: Бурханаас эмээх нь энэ газарт байхгүй нь лавтай, **Эхл.** 20:11. Чи өөрийн Бурхан Эзэнээс эмээх ёстой, **Дэд хууль** 6:13 (Иош. 24:14; 1 Сам 12:24). Эзэнд эмээн үйлчлэл, **Дуул.** 2:11. Эзэнээс эмээх нь мэргэн ухааны эхлэл мөн, **Дуул.** 111:10. Эзэнээс эмээж, чөтгөрөөс зайлагтун, **Сур.** үгс 3:7. Бурханаас эмээгч тэдэнд сайн байх болно, **Номл.** үгс 8:12. Өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр биелүүлэгтун, **Филип.** 2:12. Бурханаас эмээж, түүнд алдар сууг өг, **Илч.** 14:7 (С ба Г 88:104). Их Эзэнээс эмээх айдаст хүмүүсийг үргэлж байлгахын тулд бошиглогчид тэднийг бусниулж байв, **Инос** 1:23. Алма болон Мозаягийн хөвгүүд газарт унав, учир нь Их Эзэнээс эмээх айдас тэдэн дээр ирэв, **Алма** 36:7. Их Эзэнээс эмээж мөн сүрдснээр өөрсдийн авралыг гүйцэлдүүлэгтүн, **Морм.** 9:27. Надаас үл эмээдэг тэднийг би түйвээж мөн чичрэн дагжихаар болгоно, **С ба Г** 10:56. Надаас эмээдэг тэрээр Хүний Хүүгийн ирэлтийн тэмдгүүдийг хүсэн хүлээсээр байх болно, **С ба Г** 45:39.

Хүнээс эмээх нь: Бүү эмээ, учир нь би чамтай хамт байна, **Эхл.** 26:24 (Иса. 41:10). Эзэн бидэнтэй хамт бай-

даг, тэднээс бүү ай: **Тоол.** 14:9. Бүү эмээ: учир нь бидэнтэй хамт байдаг нь илүү олон билээ, **Хаад.** **Дээд** 6:16. Маханбодийн хийдэг зүйлээс би айхгүй, **Дуул.** 56:4. Хүний зэмлэлээс бүү ай, **Иса** 51:7 (2 Ниф. 8:7). Бурхан бидэнд айдсын сүнсийг өгөөгүй билээ, **2 Тим.** 1:7. Төгс хайр айдсыг зайлуулдаг, **1 Иохан** 4:18 (Моро. 8:16). Хиламаны хөвгүүд үхлээс айсангүй, **Алма** 56:46–48. Үхлийн айдас ёс бусчуудын цээжийг дүүргэдэг, **Морм.** 6:7. Хүмүүний юу хийхээс бүү эмээ, **Моро.** 8:16. Чи Бурханаас илүүгээр хүмүүнээс айх ёсгүй, **С ба Г** 3:7 (С ба Г 30:1; 11; 122:9). Сайныг үйлдэхээс бүү эмээ, **С ба Г** 6:33. Миний сүмд харьяалагддаг хэн ч эмээх хэрэггүй, **С ба Г** 10:55. Хэрэв та нар бэлтгэгдэх аваас та нар эмээх хэрэггүй, **С ба Г** 38:30. Өөрсдийгөө айдсаас ангид байлга, **С ба Г** 67:10. Сайхан хөгжил хөөртэй бай, мөн бүү эмээ, учир нь Их Эзэн бибээр та нартай хамт байна, **С ба Г** 68:6. Дайснуудаасаа бүү эмээ, **С ба Г** 136:17.

ЭНЭРЭЛ. Өрөвч сэтгэл; Үйлчлэл; Хайр; Халамжийг *мөн үз*

Христийн цэвэр ариун хайр (Моро. 7:47); хүмүүний үрст харуулсан хийгээд хүмүүний үрс бие биеэндээ үзүүлэх ёстой Христийн хайр (2 Ниф. 26:30; 33:7–9; Ифер 12:33–34); хамгийн дээд, хамгийн эрхэм ариун, хамгийн хүчтэй хайр бөгөөд энэ нь ердийн нэг хайр биш.

Мэдлэг ихэрхэг болгодог, харин энэрэл сургамжилдаг, **1 Кор.** 8:1. Энэрэл, цэвэр хайр, бусад бүхнийг даван гардаг ба бүхнээс илүү нь юм, **1 Кор.** 13. Тушаалуудын зорилго нь цэвэр зүрхнээс гарах хайр юм, **1 Тим.** 1:5. Ах дүүсэг нинжин сэтгэл дээрээ энэрэлийг нэм, **2 Петр** 1:7. Их Эзэн бүх хүмүүн энэрэлтэй байх ёстой хэмээн зарлиглажээ, **2 Ниф.** 26:30 (Моро 7:44–47). Та нар итгэл, найдвар, мөн энэрлийг агуулж бай, **Алма** 7:24. Их Эзэний хүмүүнд өгсөн хайр бол энэрэл юм, **Ифер** 12:33–34. Энэрэлгүйгээр хүн Эцэ-

гийнхээ эзэмшлүүдэд бэлтгэсэн байрыг өвлөж чадахгүй, **Ифер** 12:34 (Моро 10:20–21). Итгэл, найдвар, мөн энэрлийн талаарх Мормоны үгсийг Моронай бичсэн юм, **Моро**. 7 Энэрэл нь хүмүүнийг Их Эзэний ажилд тохирох болгодог, **С ба Г** 4:5–6 (С ба Г 12:8). Өөрсдийгөө энэрлийн холбоосоор хувцасла, **С ба Г** 88:125. Хэвлий чинь энэрлээр дүүрэн байг, **С ба Г** 121:45.

ЭРИН ҮЕ. Сайн Мэдээ; Сайн

Мэдээний сэргээлт; Санваар;

Санваарын түлхүүрүүдийг *мөн үз*

Сайн Мэдээний эрин үе гэдэг нь Их Эзэн энэ дэлхий дээр ариун санваарын түлхүүрүүдийг атгадаг эрх мэдэл бүхий дор хаяж нэг үйлчлэгчтэй байсан цаг хугацаа юм.

Адам, Енох, Ноа, Абрахам, Мосе, Есүс Христ, Иосеф Смит болон бусад нь бүгд сайн мэдээний шинэ эрин үеийг эхэлжээ. Их Эзэн эрин үеийг зохион байгуулахад сайн мэдээ шинээр илчлэгдэж, ингэснээр хүмүүс өнгөрсөн эрин үеийн авралын төлөвлөгөөний мэдлэгт хамаагүй болдог. Иосеф Смитээр эхэлсэн эрин үе нь цаг хугацааны бүрэн байдлын эрин үе юм.

Тэнгэрийн Бурхан хаант улсыг байгуулна, **Дан**. 2:44 (С ба Г 65). Эцсийн өдрүүдэд би бүх маханбодь дээр өөрийнхөө Сүнснийг цутгах болно, **Үйлс** 2:17 (Иоел 2:28). Бүхнийг сэргээх үе хүртэл тэнгэр Христийг хүлээн авах болно, **Үйлс** 3:21. Цагийн бүрэн дүүрэнд Бурхан бүх зүйлсийг Христэд хамтад нь цуглуулах болно, **Ефес** 1:10. Би тэдний дунд өөрийнхөө сүмийг бий болгох болно, **3 Ниф**. 21:22. Эцсийн өдрүүдэд Их Эзэн өөрийнхөө хаант улсын түлхүүрүүдийг болон сайн мэдээний эрин үеийг даатгасан билээ, **С ба Г** 27:13. Энэ эрин үеийн түлхүүрүүд та нарын гарт даатгагдсан болой, **С ба Г** 110:12–16. Цагийн бүрэн байдлын эрин үед өнгөрсөн үеийн бүх түлхүүр сэргээгдсэн бөлгөө, **С ба Г** 128:18–21.

ЭРТНИЙ ӨДӨР. Адамыг үз

ЭРҮҮЛ МЭНД. Мэргэн Ухааны Үгийг үз

ЭРХ МЭДЭЛ. Бурханаас дуудагдагдсан, Дуудах, Дуудлага; Санваар; Санваарын түлхүүрүүд; Томиллолт, Томилох; Хүчийг *мөн үз*

Бурханы ажлыг газар дэлхий дээр хийхэд Бурхан Эцэг болон Есүс Христийн нэрийн өмнөөс үйлдэхээр дуудагдсан буюу томилогдсон хүмүүст соёрхогдсон зөвшөөрөл.

Би чамайг илгээсэн билээ, **Ег**. 3:12–15. Миний чамд зарлигласан бүгдийг хэл, **Ег**. 7:2. Тэрээр арван хоёр шавьдаа хүчийг өгчээ, **Мат**. 10:1. Та нар намайг сонгоогүй, харин би та нарыг сонгосон, **Иохан** 15:16. Нифай Лихай хоёр агуу эрх мэдлээр номлов, **Хил**. 5:18. Хиламаны хүү Нифай Бурханы агуу хүч болон эрх мэдэлтэй Бурханы хүн байлаа, **Хил**. 11:18 (3 Ниф. 7:17). Есүс арванхоёр нифай хүнд хүч ба эрх мэдлийг өгөв, **3 Ниф** 12:1–2. Иосеф Смит Бурханаас дуудагдаж мөн томилогдов, **С ба Г** 20:2. Тэрээр томилогдсон бөгөөд Сүмд эрх мэдэлтэй гэдэг нь мэдэгдэхээс бусдаар хэн ч миний сайн мэдээг номлож мөн миний Сүмийг байгуулж чадахгүй, **С ба Г** 42:11. Ахлагч нар сайн мэдээг номлож, эрх мэдлээр үйлдэх ёстой, **С ба Г** 68:8. Мелкизедек санваартан сүнслэг зүйлсийг гүйцэтгэх эрх мэдэлтэй, **С ба Г** 107:8, 18–19. Тэнгэрлэг эрх мэдэл хууль болоход юу болох вэ, **С ба Г** 128:9. Бурханы тул номлох болон гүйцэтгэх хэн ч байсан Бурханы эрх мэдэлтэй нэгнээр дуудагдах ёстой, **ИТ** 1:5.

ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУГ. Ахмад Моронайг *мөн үз*

Мормоны Номын Нифайн их цэргийн ерөнхий жанжин Моронайг өргөсөн туг. Нифайн хүмүүсийг өөрсдийнхөө шашин, эрх чөлөө, амар амгалан хийгээд гэр бүлээ

хамгаалахад зоригжуулахаар Моронай уг тугийг хийсэн ажээ.

Моронай эрх чөлөөний тугийг урсан хувцсаараа хийв, **Алма** 46:12–13. Энэ тугийг хадгалах бүхэн гэрээнд орж байв, **Алма** 46:20–22. Моронай цамхаг бүр дээр тугийг өргөгдөхөөр болгов, **Алма** 46:36 (**Алма** 51:20).

ЭСРЭГ ТАЛ, СӨРӨГ ТАЛ.

Бэрхшээлийг үз

ЭСЭРГҮҮЦЭЛ. Аллага; Нүгэл;

Урвалт; Чөтгөрийг мөн үз

Их Эзэнийг сөрөн эсэргүүцэж, түүнчлэн түүний сонгосон удирдагчдыг дагахаас татгалзаж түүний зарлигуудыг санаатайгаар дагахгүй байх.

Эзэний эсрэг та нар бүү тэрсэл, **Тоол**. 14:9. Тэрслүү хүн зөвхөн хорон мууг эрдэг, **Сур. үгс** 17:11. Дуулгаваргүй хүүхдүүд гаслантай яа, **Иса**. 30:1. Өөрийг нь эсэргүүцдэг мөн нүглүүддээ үхэх хэнийг боловч Их Эзэн үл гэтэлгэнэ, **Моз**. 15:26. Амлисайчууд Бурханы эсрэг илэрхий эсэргүүцэлд гарч ирсэн байв, **Алма** 3:18–19. Эсэргүүцэгчид туйлын их зовлонд нэрвэгдэх болно, **С ба Г** 1:3. Их Эзэний уур эсэргүүцэгчдийн эсрэг дүрэлзэж байна, **С ба Г** 56:1 (**С ба Г** 63:1–6). Сатан Бурханы эсрэг бослого гаргасан юм, **Моце** 4:3.

ЭХ. Гэр бүл; Ева, Эцэг эхчүүдийг мөн үз

Хүүхэд төрүүлсэн буюу үрчилж авсан эмэгтэйд ханддаг ариун нэр. Бурханы сүнсэн хүүхдүүдийг мөнх бус бие махбодиор хангаснаар эхчүүд Бурханы төлөвлөгөөнд тусалдаг.

Адам эхнэрээ Ева гэж нэрлэжээ. Учир нь тэр амьд бүхний эх болсон ажээ, **Эхл.** 3:20 (**Моце** 4:26). Эцэг эхээ хүндэл, **Ег.** 20:12 (**Ефес.** 6:1–3; **Моз.** 13:20). Эхийнхээ зааврыг бүү оооор, **Сур. үгс** 1:8. Муухаг хүн эхийгээ басамжилдаг, **Сур. үгс** 15:20

(**Сур. үгс** 10:1). Эхийгээ өглөхөд нь бүү үл тоомсорлоорой, **Сур. үгс** 23:22. Үр хүүхдүүд нь өсөж өндийгөөд түүнийг ерөөнө, эр нөхөр нь ч гэсэн түүнийг магтана, **Сур. үгс** 31:28. Есүсийн эх загалмайн дэргэд зогсож байв, **Иохан** 19:25–27. Леменчүүдийн хоёр мянган дайчид эхчүүдээрээ заагдан сургагдаж байлаа, **Алма** 56:47 (**Алма** 57:21). Их Эзэн сүнсний ертөнцөд тэднийг зааварласан агуу хийгээд хүчирхэг тэдний дунд бидний алдар суут Эх Ева байлаа, **С ба Г** 138:38–39.

ЭХЛЭЛ. Пентатеухыг мөн үз

“Гарал” буюу “Эхлэл” гэсэн утгатай грек үг. Эхлэл Ном бол Хуучин Гэрээний эхний ном бөгөөд бошиглогч Мосегоор бичигджээ. Энэ нь дэлхий бүтээгдсэн, дэлхий дээр амьтад болон хүнийг байршуулсан хийгээд Адам Ева хоёрын уналт, Адамд сайн мэдээний илчилсэн, овгууд болон үндэстнүүдийн эхлэл, Бабел дахь олон хэлний гарал, түүнчлэн Израилын угсааны үндэслэн байгуулалт өөд хөтөлсөн Абрахамын гэр бүлийн эхлэл мэтийн олон эхлэлүүдийн тухай шастирыг өгүүлдэг. Израилыг хадгалж үлдээхэд гүйцэтгэсэн Иосефын үүргийг Эхлэлд онцлон тэмдэглэсэн байдаг.

Хожмын үеийн илчлэлт Эхлэлийн цэдгийг нотлон, тодруулдаг (1 Ниф. 5; Ифер 1; Моце 1–8; Абр. 1–5).

Эхлэлийн Номонд бүлэг 1–4 нь дэлхийг бүтээсэн болон Адамын гэр бүлийн хөгжилтийн тухай өгүүлдэг. Бүлэг 5–10 нь Ноагийн түүхийг өгүүлдэг. Бүлэг 11–20 нь Абрахам болон түүний гэр бүлийн тухай Исаакийн үеийг хүртэл өгүүлдэг. Бүлэг 21–35-д Исаакийн гэр бүлийн тухай гардаг. Бүлэг 36 нь Есав болон түүний гэр бүлийн тухай өгүүлдэг. Бүлэг 37–50 нь Иаковын гэр бүлийн тухай хүүрнэж, Иосеф Египетэд худалдагдсан тухай хийгээд Израилын угсааг аврахад түүний гүйцэтгэсэн үүргийн тухай шастирыг агуулдаг.

ЭХЛЭЛ. Бүтээх, Бүтээлт; Есүс Христ; Мөнх бус байдлын өмнөх амьдралыг *мөн үз*

Ерөнхийдөө энэхүү мөнх бус байдлын өмнөх үеийг хэлдэг—энэ нь мөнх бус байдлын өмнөх амьдрал юм. Заримдаа Есүсийг Эхлэл хэмээн нэрлэдэг.

Эхлэлд Бурхан тэнгэр болон газрыг бүтээжээ, **Эхл.** 1:1 (Моце 2:1). Эхлэлд Үг байв, **Иохан** 1:1. Би Альфа ба Омега, эхлэл ба төгсгөл билээ, **3 Ниф.** 9:18. Христ бол эхлэл ба төгсгөл, **С ба Г** 19:1. Шинэ бөгөөд үүрдийн гэрээ нь эхлэлээс байсан билээ, **С ба Г** 22:1. Хүмүүн эхлэлд Бурхантай хамт байв, **С ба Г** 93:23, 29. Ухаалаг болон агуу сүнснүүдийг эхлэлд удирдагчид байхаар сонгожээ, **С ба Г** 138:55. Миний Төрсөн Ганц эхлэлээс надтай хамт байсан болой, **Моце** 2:26.

ЭХНЭР. Гэр бүл; Гэрлэлт, Гэрлэхийг үз

ЭЦСИЙН ӨДРҮҮД, ХОЖМЫН ӨДРҮҮД. Есүс Христийн Хоёр дахь Ирэлт; Цаг хугацааны тэмдгүүдийг *мөн үз*

Эдүгээ бидний амьдарч буй цаг үе. Энэ цаг үе (цаг хугацааны эрин үе) нь Их Эзэний Хоёр дахь Ирэлтийн өмнөх үе юм.

Би ирээдүйд юу болох тухай та нарт хэлж өгье, **Эхл.** 49:1. Гэтэлгэгч хожмын өдөр газар дэлхий дээр байр сууриа эзэлнэ, **Иов** 19:25. Эцсийн өдрүүдэд ЭЗЭНий өргөө үндэслэн байгуулагдах болно, **Иса.** 2:2. Эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирэх болно, **2 Тим.** 3:1–7. Эцсийн өдрүүдэд элэглэн дооглогчид Хоёр дахь Ирэлтийг үгүйсгэх болно, **2 Петр** 3:3–7. Хожмын өдрүүдийн тухай би та нарт бошиглоё, **2 Ниф.** 26:14–30. Эцсийн өдрүүдэд миний сүм, бүр Есүс Христийн Хожмын үеийн Гэгээнтнүүдийн Сүм тийн нэрлэгдэх болно, **С ба Г** 115:4. Христ эцсийн өдрүүдэд ирэх болно, **Моце** 7:60.

ЭЦЭГ, МӨНХ БУС. Гэр бүл; Патриарх, Патриархын; Патриархын адислалууд; Эцэг эхчүүдийг *мөн үз*

Хүүхдийн төрсөн эцэг буюу хүүхэд үрчилж авсан эрэгтэй хүнд хандсан ариун нэр.

Эцэг эхээ хүндэл, **Ег.** 20:12 (Дэд хууль 5:16; **Мат.** 19:19; **Моз.** 13:20). Хүүгээ таалдаг эцэг хүн түүнийг зэмлэдэг, **Сур. үгс** 3:12. Эцгүүд ээ, та нар хүүхдүүдээ бүү уурлуул, **Ефес** 6:1–4. Миний бие эцгийнхээ бүхий л эрдэм мэдлэгт зарим талаар сургагдав, **1 Ниф.** 1:1. Миний эцэг шударга хүн байсан, учир нь тэрээр надад заадаг байв, **Инос** 1:1. Алма хүүгийнхээ төлөө залбирав, **Моз.** 27:14. Алма хөвгүүдээ зарлигууд өгөв, **Алма** 36–42. Хиламан хөвгүүдээ өвөг дээдсийнх нь нэрийг өгөв, **Хил.** 5:5–12. Мормон залбирлууддаа хүүгийнхээ тухай үргэлж анхаардаг байв, **Моро.** 8:2–3. Агуу зүйлүүд эцгүүдийн гараас шаардагдах болно, **С ба Г** 29:48. Хүн бүр өөрийнхөө гэр бүлийн төлөө хангах үүрэгтэй, **С ба Г** 75:28. Намайг эцэг уруугаа оч хэмээн тэрээр зарлиглав, **ИС—Т** 1:49.

ЭЦЭГ ЭХЧҮҮД. Мөнх бус эцэг; Эхийг *мөн үз*

Эцгүүд болон эхчүүд. Бурханы ариун сүмд гэрлэлтэд зохих ёсоор лацдагдсан эр нөхрүүд болон эхнэрүүд бүх үүрд мөнхийн туршид эцэг эхийнхээ үүргийг гүйцэтгэх болно.

Хүүхдүүд ээ, эцэг эхээ дага, **Ефес** 6:1–3 (Кол. 3:20). Адам, Ева хоёр бидний анхны эцэг эх байлаа, **1 Ниф.** 5:11. Зүхэл та нарын эцэг эхийн толгой дээр ирж болно, **2 Ниф.** 4:6. Тэд наманчилж, мөн баптисм хүртсэн байх ёстойг эцэг эхчүүдэд сурга, **Моро.** 8:10. Хүүхдүүддээ сайн мэдээг заахаар эцэг эхчүүд зарлиг болгогддог, **С ба Г** 68:25. Бүх хүүхдүүд өөрсдийгөө тэтгүүлэхийн тулд эцэг эхэсээ нэхэх эрхтэй, **С ба Г** 83:4.

Эцэг эхчүүдийн нүгэл хүүхдүүдийнх нь толгой дээр хариулагдаж болохгүй, **Моце** 6:54.

ЯДУУ, ЯДУУС. Даруу, Даруу байдал; Мацаг барилт, Мацаг барих; Өглөг, Өглөг өгөх; Өргөл; Халамжийг *мөн үз*

Судруудад ядуу гэдэг нь (1) хүнс, хувцас, гэр орон зэрэг зайлшгүй шаардлагатай эд материалын зүйлүүд байхгүй хүмүүс, эсвэл (2) даруу, бардамналгүй хүмүүсийг хэлдэг.

Эд юмсаар ядуу: Чи тэр ядуу ах дүүгээсээ гараа бүү тат, **Дэд хууль** 15:7. Хорон санаат хүн бардам зангаараа ядуусыг хавчдаг, **Дуул.** 10:2. Ядууст өгдөг хүн юугаар ч дутагдахгүй, **Сур.** **үгс** 28:27. Ядуусыг гиртэг оруул, **Иса.** 58:6–7. Хэрэв чи тогс байхыг хүсдэг бол, ядууст өг, **Мат.** 19:21 (Марк 10:21; Лук 18:22). Бурхан энэ дэлхийн ядуусыг сонгоогүй гэж үү? **Иаков** 2:5. Тэд баян учраас ядууг гадурхдаг, **2 Ниф.** 9:30. Өөрсдийн нүглүүдийн ангижралыг хадгалан үлдэхийн тулд ядуустай хөрөнгөө хуваалц, **Моз.** 4:26. Тэд өөрсдийн хөрөнгөнөөс ядуустай хуваалцаж байсан болой, **Алма** 1:27. Хэрэв та нар гачигдсан тэднээс нүүр буруулбал, та нарын залбирлууд хоосон юм, **Алма** 34:28. Нифайчууд өөрсдийн дунд бүх зүйлийг нийтээр эзэмшиж байв; баячууд хийгээд ядуус гэж байсангүй, **4 Ниф.** 1:3. Чи ядуусыг санах ёстой, **С ба Г** 42:30 (С ба Г 52:40). Зүрх сэтгэл нь харуусдаггүй ядууст халаг, **С ба Г** 56:17–18. Ядуус Хурганы гэрлэлтэд ирэх болно, **С ба Г** 58:6–11. Бишоп ядуусыг эрж олох ёстой, **С ба Г** 84:112. Сайн мэдээний хууль ядууст анхаарал халамж тавих явдлыг удирдан зохицуулдаг, **С ба Г** 104:17–18. Тэдний дунд ядуус байсангүй, **Моце** 7:18.

Сүнсээр ядуу: Ядуугийн учир даруу байхаар өөрсдийгөө албадуулдаггүй тэд илүү адислагдсан болой, **Алма** 32:4–6, 12–16. Надад ирдэг сүнсэндээ ядуу тэд адислагдсан

болой, **3 Ниф.** 12:3 (Мат. 5:3). Ядуу хийгээд номхон нь өөрсдөд нь номлогдсон сайн мэдээтэй байх болно, **С ба Г** 35:15.

ЯЛ. Мөхлийн хөвгүүд; Сүнсний үхэл; Там; Чөтгөрийг *мөн үз*

Хүний өсөлт хөгжилтийн түвшин зогсож, Бурханы оршихуй хийгээд түүний алдар сууд очих нь үгүйсгэгдэх байдал. Яланд олон түвшин байдаг. Селестиел өргөмжлөлийн дүүрнийг олж аваагүй бүх хүмүүс өөрсдийн өсөлт хөгжилт хийгээд онцгой боломжуудад хязгаарлагдсан зарим зэрэглэлийг олж авах бөгөөд тэд тэрхүү хүрээндээ яллагдах болно.

Хоёр нүүртнүүд золгүй еэ! Та нар илүү хүнд шийтгэл хүлээнэ, **Мат.** 23:14. Ариун Сүнснийг доромжлогч хүн мөнх нүглийн гэмтэн болдог, **Марк** 3:29. Муу үйлийг үйлдсэн хүмүүс ялын амилалт уруу гарч ирнэ, **Иохан** 5:29 (3 Ниф. 26:5). Зөв бусаар идэж мөн уух хүн өөртөө ялыг идэж мөн уудаг, **1 Кор.** 11:29 (3 Ниф. 18:28–29). Наманчилж, мөн баптисм хүртэж, эцсээ хүртэл тэвчихгүй аваас яллагдах ёстой, **2 Ниф.** 9:24 (Марк 16:16; Ифер 4:18; С ба Г 68:9; 84:74). Хилэнцтийг үйлдэгч та нар Бурхантай хамт оршихдоо, та нар тамд ялагдсан бодгалиудтай оршсоноос илүү зовлонтой байх болно, **Морм.** 9:4. Түүнд зарлиглах хүртэл юу ч хийдэггүй тэр нь яллагддаг бөлгөө, **С ба Г** 58:29. Шинэ бөгөөд үүрдийн гэрээг бүрнээр нь хүлээн авсан тэрээр хуулийг сахиж ёстой, эсвээс тэрээр яллагдах болно, **С ба Г** 132:6.

ЯЛГАН ТАНИХ БЭЛЭГ. Сүнсний бэлгүүдийг *мөн үз*

Аливаа зүйлийг Сүнсний хүчээр ойлгож, мэдэх. Ялган таних бэлэг нь Сүнсний бэлгүүдийн нэг юм. Хүмүүсийн үнэн зан чанар болон сүнсний тунхаглалуудын утга учир, эх сурвалжийг мэдэх нь үүнд хамаардаг.

Хүн гаднах төрхийг хардаг, харин

Их Эзэн зүрхийг нь хардаг, **1 Сам.** 16:7. Ёс бусыг сайн хэмээн дуудагсдад халаг, **Иса.** 5:20 (2 Ниф. 15:20). Бурханы зүйлүүд сүнсээр үзэгддэг, **1 Кор.** 2:14. Бас өөр нэгэнд нь сүнснүүдийг ялган таних нь өгөгдсөн бөлгөө, **1 Кор.** 12:10. Аммон түүний бодлуудыг мэдэж чадсан байв, **Алма** 18:18, 32. Намуухан дуу хоолой тэдний биеийнх нь төвд орж тэднийг сонсох болгов, **3 Ниф.** 11:3. Мэхлэгдэхгүй байхын тулд хамгийн шилдэг бэлгүүдийг эрэлхийл, **С ба Г** 46:8, 23. Сүмийн удирдагчдад Сүнсний бэлгүүдийг ялган таних хүч өгөгдсөн билээ, **С ба Г** 46:27. Гэрлээр дүүргэгдсэн бие бүх зүйлийг ойлгодог, **С ба Г** 88:67. Мосе дэлхийг болгоов, үүнийг Бурханы Сүнсээр ялган танив, **Мосе** 1:27.

ЯЛТСУУД. Алтан ялтсууд;
Мормоны Номыг *мөн үз*

Эрт үед зарим улс орон өөрсдийн түүх болон цэдгүүдийг төмөрлөг ялтсууд дээр, жишээ нь Мормоны Номны адилаар бичдэг байжээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг Мормоны Номны оршил хуудсууд дээрх “Мормоны Номны тухай товч тайлбараас” үз.

ЯНГ, БРИГАМ

Энэ эрин үеийн анхны Төлөөлөгч бөгөөд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хоёрдахь ерөнхийлөгч. Тэрээр гэгээнтнүүдийг Науву, Иллинойгоос өрнөд уруу Солт Лейкийн Хөндий уруу удирдан дагуулсан бөгөөд Нэгдсэн Улсын өрнөд нутаг дахь агуу эзэмшигч байлаа.

Бригам Янг Арванхоёр Төлөөлөгчийн Ерөнхийлөгч байхаар дуудагдав, **С ба Г** 124:127. Бригам Янг өөрийнхөө хөдөлмөрүүд болон хилийн чанд уруу хийх ирээдүйн аялаас чөлөөлөгдөхөөр зарлигдуулжээ, **С ба Г** 126. Гэгээнтнүүд өрнө зүгт хийх аяллаа хэрхэн зохион байгуулахыг Их Эзэн Бригам Янгад зааварчилжээ, **С ба Г** 136. Бригам Янг сүнсний дэлхийд сонгогдогсдын дунд байв, **С ба Г** 138:53.

БИБЛИЙН ИОСЕФ СМИТИЙН ОРЧУУЛГААС АВСАН ТҮҮВРҮҮД

Библийн Хаан Жеймсийн хувилбараас Иосеф Смитийн орчуулсан (ИСО) хэсгүүдийн түүврийг дор харуулав. Анхны үгс бичигдсэнээс хойш алга болсон буюу өөрчлөгдсөн үнэнүүдийг Библийн эх сэдэвт сэргээхэд Их Эзэн, Бошиглогч Иосеф Смитийг урамшуулжээ. Эдгээр сэргээгдсэн үнэнүүд сургаалыг тодосгож, судруудыг ойлгох явдлыг сайжруулсан байна. Удирдамжид сонгож авсан хэсгүүд нь ямар хэлэнд орчуулагдсанаас үл хамааран судруудын талаарх та бүхний ойлголтыг сайжруулахад туслах болно.

Анхны зохиогчдын нэгэнт цэдэглэсэн үнэнүүдийг Их Эзэн Иосеф Смитэд илчилсэн учир, Иосеф Смитийн орчуулга нь дэлхий дэх Библийн өөр ямар ч орчуулгатай адилгүй юм. Энэ утгаараа, орчуулга гэдэг үг ердийнхөөсөө илүү өргөн хийгээд өөр байдлаар хэрэглэгддэг, учир нь Иосеф Смитийн орчуулга бол ердөө л нэг хэлнээс нөгөөд хөрвүүлсэн орчуулга гэхээс илүү илчлэлт байлаа. ИСО-ын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Удирдамж дахь цагаан толгойн дэс дарааллаарх сэдвийн жагсаалт дахь Иосеф Смитийн Орчуулгаас үз.

ИСО-аас авсан түүврийн загварыг дор харуулав:

Түүний орчуулга Библийн эх сэдэвт үгсийг сэргээсэн учир шүлгүүдийн дугаар нь таны ашиглаж буй хэвлэлийнхээс өөр байж болно.

ИСО, Матай 4:1, 5–6, 8–9 (Матай 4:1, 5–6, 8–9-тэй харьцуул; мөн үүнтэй адил өөрчлөлтүүд Лук 4:2; 5–11-д хийгджээ). Иосеф Смитийн орчуулгатай таны харьцуулах ёстой Библийн ишлэл хаалтан дотор байгаа болно.

(Есүс Сатанаар биш, Сүнсээр хөтлөгдөв.)

1 Тийнхүү Есүс Бурхантай хамт байхаар цол уруу Сүнсээр хөтлөгдөв.

5 Тэгээд Есүс ариун хотод аваачигдан, мөн Сүнс түүнийг ариун сүмийн орой дээр тавив.

6 Тэгтэл чөтгөр түүн дээр хүрч ирэн хэлсэн нь, Хэрэв чи Бурханы хүү юм бол, өөрийгөө доош хая; учир нь энэ нь бичигдсэн билээ, Тэрээр чиний талаар тэнгэр элчүүддээ санаа тавихыг үүрэг өгөх болно; мөн ямар ч үед чи хөлөөрөө чулуу өшиглөхгүйн тулд тэд чамайг гар дээрээ авч явах болно.

8 Мөн дахин, Есүс Сүнсэн дотор байв, мөн энэ нь түүнийг үлэмж өндөр ууланд аваачиж, тэгээд дэлхийн бүх хаант улсууд хийгээд тэдгээрийн алдар сууг түүнд харуулав.

9 Мөн чөтгөр түүн дээр дахин хүрч ирэн, эдгээр бүх зүйл байх болно хэмээн хэлэв.

Тод үсгээрх ишлэл нь Хаан Жеймсийн Библиэс Иосеф Смитийн хийсэн орчуулгын хэсэг юм.

Энэхүү нотолгоо нь Иосеф Смит өөрийнхөө орчуулгаар ямар сургаалыг тодруулсныг тайлбарладаг.

Энэ бол Иосеф Смитийн орчуулсан эх сэдэв юм.

ИСО, Эхлэл 9:10–15 (Эхлэл
9:3–9-тэй харьцуул)

*(Аллага хийгээд мөн түүнчлэн амьт-
дын амь бүрэлгэсний төлөө хүмүүн ха-
риуцлага хүлээх болно.)*

10 Гэвч та нарт хоол хүнсний тулд миний өгсөн бүх маханбодийн цус газар дээр урсах болно, тэдний амийг авдаг тэрхүү цусыг та нар идэх ёсгүй.

11 Мөн та нарын амьдралыг авра-хын тулд зөвхөн хоол хүнсний тулд биш аваас, цус урсах ёсгүй; мөн амьтан болгоны цусыг би та нарын гараас шаардах болно.

12 Мөн хүмүүний цус урсгасан хэн боловч, түүний цус хүмүүнээр урс-гагдах болно; учир нь хүмүүн хү-мүүний цусыг урсгах ёсгүй.

13 Учир нь хүмүүний ахан дүүс хү-мүүний амийг хамгаалах ёстой хэ-мээх зарлигийг би өгч байна, учир нь би өөрийн дүр төрхөөр хүмүү-нийг бий болгосон билээ.

14 Мөн үржилтэй байж, өсч үрж-түгэй хэмээх зарлигийг би та нарт өгч байна; газар дэлхийд элбэг дэл-бэгээр урагш авчирч мөн тэндээ өсөн үржигтүн хэмээх зарлигийг би та нарт өгч байна.

15 Ноад болон түүний хамт хөвгүү-дэд нь Бурхан хандан хэлэхдээ, Мөн болгоогтун, та нарын дараах та нарын үр удмын талаар би та на-рын эцэг Енохтой хийсэн гэрээгээ та нартай байгуулах болно гэв.

ИСО, Эхлэл 9:21–25 (Эхлэл
9:16–17-той харьцуул)

(Енох болон Ноатай байгуулсан Бурха-ны гэрээний сануулга болон тэнгэрт солонго тавигдсан байлаа. Эцсийн өд-рүүдэд Ууган Хүүгийн сүмийн ерөнхий хуралдай (Енохын үе дэх Их Эзний Сион; Мосе 7-г үз) дэлхий дээрх зөв шу-дарга хүмүүсийг нэгтгэх болно.)

21 Мөн солонго нь үүлэн дотор байх болно; мөн би чиний эцэг Енохтой хийсэн үүрдийн гэрээг; хүмүүн миний бүх зарлигуудыг сахьсан үед би өөртөө дээш нь ав-

чирсан Енохын хот Сион дэлхий дээр дахин ирэх үүрдийн гэрээг би санаж болохын тулд би үүнийг ха-рах болно.

22 Чиний үр удам үнэнийг хүлээн авч, өөдөө харсан үед, Сион доош харж, мөн бүх тэнгэр баярлан сэгс-рэгдэж, мөн дэлхий баяр баясга-лангаар чичрэх болно гэдэг нь ми-ний үүрдийн гэрээ бөлгөө.

23 Мөн Ууган Хүүгийн сүмийн ерөнхий хуралдай тэнгэрээс доош бууж ирэн, мөн дэлхийг эзэмшин тэгээд төгсгөл иртэл байх болно. Мөн энэ бол чиний эцэг Енохтой миний хийсэн миний үүрдийн гэр-рээ бөлгөө.

24 Мөн тэнгэрт солонго байх болно, мөн бибээр чи бид хоёрын хооронд миний хийсэн тэрхүү гэрээгээ дэл-хий дээр байх бүх амьд махан бо-дийн төлөө би байгуулах болно.

25 Мөн Бурхан Ноад хэлсэн нь, энэ бол чи бид хоёрын хооронд миний байгуулсан гэрээний дохио мөн; дэлхий дээр байх бүх махан бодийн төлөө буюу.

ИСО, Эхлэл 14:25–40 (Эхлэл
14-тэй харьцуул)

(Мелкизедекийн агуу тохинуулал дур-дагдав; Мелкизедек санваарын хүчнүүд хийгээд адислалууд дүрслэгдэв.)

25 Мөн Мелкизедек дуу хоолойгоо өргөж түүнчлэн Абрахамыг адислав. 26 Эдүгээ Мелкизедек зөв шудар-га ёсыг авчирсан итгэл бүхий хүн байв; мөн тэрээр балчир хүүхэд байхдаа Бурханаас эмээдэг байв, түүнчлэн хэвлийн амуудыг зог-соож, мөн түрэмгий галыг унтраав.

27 Мөн ийнхүү, тэрээр Бурханаас зөвшөөрөгдөн, Енохтой Бурханы хийсэн гэрээний жаягийн дагуу дээд санваартнаар томилогдсон байв,

28 Энэ нь Бурханы Хүүгийн жая-гийн дагуу байв; уг жаяг нь хүмүү-нээр мөн хүмүүний хүсэл зоригоор ирээгүй юм; мөн эцгээр буюу эхээр ч бус; мөн өдрүүдийн эхлэл буюу жилүүдийн төгсгөлөөр ч бус; харин Бурханаас болой;

29 Мөн энэ нь түүний өөрийнх нь дуу хоолойн дуудлагаар, түүний өөрийнх нь тааллын дагуу, түүний нэрэнд итгэдэг бүх хүмүүст хүргэгдсэн байлаа.

30 Учир нь энэ жаяг хийгээд дуудлагын дагуу томилогдох хүн болгон, итгэлээр уулсыг нурааж, тэнгисийг хувааж, усыг ширгээж, урсгалыг нь өөрчлөх хүчтэй байх ёстой хэмээн Енох болон түүний үр удамд өөрөө Бурхан андгай тавин тангарагласан юм;

31 Үндэстнүүдийн их цэргийг бут ниргэлтэд тавьж, газар дэлхийг хуваан, хүлээс бүрийг эвдэж, Бурханы оршихуйд зогсох, бүх зүйлийг түүний тааллын дагуу, түүний зарлигийн дагуу хийж, вант улсууд хийгээд гүрнүүдийг захирахын тулд буюу; мөн энэ нь дэлхийн сууринаас өмнө байсан Бурханы Хүүгийн тааллаар бөлгөө.

32 Мөн ийм итгэлтэй байж, мөн Бурханы энэхүү жаягт ирсэн хүмүүс тэнгэрт зөөгдөн аваачигдсан билээ.

33 Мөн эдүгээ, Мелкизедек бол энэхүү жаягийн санваартан байв; тиймийн тул тэрээр Салемд амар амгалангийн Хунтайж хэмээн нэрлэгдэж байв.

34 Мөн түүний хүмүүс зөв шударгыг үйлддэг байж, мөн тэнгэрийг олж аван, түүнчлэн өмнө нь үүнийг дэлхийгээс тусгаарлаж, хожмын үеийн эсвээс дэлхийн төгсгөлийн тулд аваачсан Енохын хотыг эрэлхийлдэг байв.

35 Мөн тэнгэр хийгээд газар дэлхий нийлж; мөн Бурханы хүүхдүүд галаар мэт соригдох ёстой хэмээн тангараглаж хэлсэн билээ.

36 Мөн энэхүү Мелкизедек ийнхүү зөв шударга ёсыг үндэслэн, түүний хүмүүсээр, тэнгэрийн хаан, эсвээс өөр үгээр энх амгалангийн Хаан хэмээн нэрлэгддэг байв.

37 Мөн тэрээр дуу хоолойгоо өргөн мөн тэрээр дээд санваартан, Бурханы агуулахын эзэний хувиар Абрахамыг адислав;

38 Ядуусын төлөө аравны нэгийг

хүлээн авахаар Бурханы томилсон түүнийг буюу.

39 Иймийн тул, Абрахам өөртөө байсан бүхнээс мөн өөрийн эзэмшиж байсан бүх баялгаас аравны нэгийг түүнд төлдөг байв.

40 Мөнхүү улиран тохиох дор өөрийн хийсэн гэрээний дагуу, Мелкизедек түүнийг адисалсан тэрхүү адислалын дагуу Бурхан Абрахамыг адисалж, мөн эд баялаг, нэр төр хийгээд үүрд эзэмших нутгудыг түүнд өгчээ.

ИСО, Эхлэл 15:9–12 (Эхлэл 15:1–6- тай харьцуул)

(Абрахам Бурханы Хүүг үзэгдэлд харж мөн амилуулалтын тухай мэдэж авав.)

9 Ингээд Абрахам хэлэв, Их Эзээн, та энэ нутгийг үүрдийн өвийн тулд надад хэрхэн өгөх вэ?

10 Мөн Их Эзэн айлдав. Чамайг нас нөгчлөө ч гэсэн, би үүнийг чамд өгч чадахгүй гэж үү?

11 Мөн хэрэв чи нас нөгчлөө ч гэсэн, чи үүнийг эзэмшсээр байх болно, учир нь Хүний Хүү амьдрах тэр өдөр ирнэ; гэвч хэрэв тэрээр наснаас эс халих аваас, тэрээр хэрхэн амьдарч чадах билээ? Тэрээр анх түрүүн амилагдах ёстой.

12 Мөнхүү улиран тохиох дор, Абрахам урагш харж, мөн Хүний Хүүгийн өдрүүдийг үзэв, мөн баяртай байлаа, мөн түүний бодгаль амрав, мөн тэрээр Их Эзэнд итгэдэг байв; мөн Их Эзэн үүнийг түүний зөв шударга байдал хэмээн тооцов.

ИСО, Эхлэл 17:3–7, 11–12 (Эхлэл 17:3–12-той харьцуул)

(Бурхан хөвч хөндөх тухай гэрээг Абрахамтай байгуулав. Баптисмын ёслол хийгээд хүүхдүүд хариуцлага хүлээх нас Абрахамд илчлэгдэв.)

3 Мөнхүү улиран тохиох дор, Абрахам нүүрээрээ унаж, мөн Их Эзэний нэрийг дуудав.

4 Мөн Бурхан түүнтэй ярьж, хэлсэн нь, Миний хүмүүс миний зарчмуудаас холдож, мөн тэдний эцгүүдэд өгсөн ёслолуудыг минь сахьсангүй;

5 Мөн тэд миний тослох ёслолыг мөн миний тэдэнд зарлигласан оршуулга буюу баптисмыг сахсангүй;

6 Харин уг зарлигаас эргэж, хүүхдийн угаалга, түүнчлэн цус шүршилтийг өөрсдөдөө авчээ.

7 Мөн зөв шударга Абелын цус нүглийн улмаас урссан хэмээн хэллээ; мөн тэд миний өмнө юугаар хариуцлага хүлээхийг мэдсэнгүй.

11 Мөн бибээр хөвч хөндөх тухай гэрээг чамтай байгуулах болно. Мөн энэ нь чи бид хоёрын хоорондох мөн чиний дараах чиний үр удам хийгээд тэдний үеийнхний хоорондох миний гэрээ байх болно; хүүхдүүд найман нас хүртлээ миний өмнө хариуцлага хүлээх ёсгүйг чи үүрд мөнхөд мэдвэл зохино.

12 Мөн чиний эцгүүдтэй миний байгуулсан бүх гэрээг чи сахиж болно; мөн чамд миний өөрийн амаар өгсөн зарлигуудыг чи сахиж ёстой, мөн чамд болон чиний дараах үр удамд чинь би Бурхан байх болно.

ИСО, Эхлэл 17:23 (Эхлэл 17:17-той харьцуул)

(Исаак төрөх тухай угтан хэлэгдэхэд Абрахам баясав.)

23 Тэгэхэд Абрахам нүүрээрээ унаж, баясан, мөн зүрх сэтгэлдээ хэлсэн нь, Зуун настай түүнд нэг хүүхэд төрөх болно, мөн ерэн настай Сара түүнийг тээх болно.

ИСО, Эхлэл 19:9–15 (Эхлэл 19:5–10-тай харьцуул)

(Содомын ёс бус явдлыг Лот эсэргүүцэв.)

9 Мөн тэд түүнд хэлэв, Гэдрэгээ бол. Мөн тэд түүнд ууртай байв.

10 Мөн тэд өөр хоорондоо ярилцсан нь, Энэ нэг хүн бидний дунд орж ирээд, бас эдүгээ өөрийгөө шүүгч болгох санаатай байна; эдүгээ түүний тэдэнтэй харьцахаас илүү муугаар бид түүнтэй харьцах болно.

11 Иймийн тул тэд нөгөө хүнд хэлэв, тэр эрчүүд, мөн бас чиний охид бидэнд байх болно; мөн бидэнд сайн санагдсанаар бид тэдэнтэй үйлдэх болно.

12 Эдүгээ энэ нь Содомын тэрхүү ёс бусын дагуу байлаа.

13 Мөн Лот ирэв, Эдүгээ болгоогтун, Эр хүнийг үл мэдэх хоёр охин надад буй; залбирч тэднийг та нарт би авчрахгүй байж болохын тулд ах нараасаа гуйн би та нарт залбиръя; мөн та нар өөрсдийн нүдэнд сайн санагдсанаар тэдэнтэй үйлдэх ёсгүй;

14 Учир нь энэ зүйлд Бурхан өөрийн үйчлэгчийг зөвтгөх нь үгүй; тиймийн тул, эдгээр эрчүүдтэй та нар юуг ч үйлдэхгүй байхыг, тэд миний гэрт амар амгалан байж болохын тулд, зөвхөн энэ зүйлийг би ах нараасаа гуйя; учир нь иймийн тул тэд миний дээврийн сүүдэр дор ирсэн болгоо.

15 Мөн тэд Лотод ууртай байв, мөн хаалгыг эвдэхээр ойртож ирсэн боловч, ариун хүмүүс байсан Бурханы тэнгэр элчүүд гараа сунгаж, Лотыг байшин дотор өөрсөд дээрээ татан авч, тэгээд хаалгыг хаав.

ИСО, Эхлэл 48:5–11 (Эхлэл 48:5–6-тай харьцуул)

(Иосефын үр удам хожмын өдрүүдэд Израилыг цуглуулахад удирдагчид байх болно.)

5 Мөн эдүгээ, намайг Египетэд чам дээр очихоос өмнө Египетийн нутагт чамд төрсөн чиний хоёр хөвгүүн Ефраим, Манассе нар, болгоогтун, тэд минийх болой мөн Реубен, Симеон хоёр адислагдахын адилаар миний эцгүүдийн Бурхан тэднийг адислах болно, учир нь тэд минийх билээ; иймийн тул тэд миний нэрээр нэрлэгдэх болно. (Тиймийн тул, тэд Израил хэмээн нэрлэгддэг байв.)

6 Тэдний дараа чамаас төрсөн хүүхдүүд чинийх байх болно, мөн тэд өөрсдийн өвүүдэд, овгуудад ах нарынхаа нэрээр нэрлэгдэх болно; тиймийн тул тэд Манассегийн болон Ефраимын овгууд хэмээн нэрлэгдэх болно.

7 Мөн Иаков Иосефт хэлсэн нь, Каанааны нутаг, Люзэд над дээр хүрч

ирэхдээ уг нутгийг үүрдийн эзэмшил болгон, мөн миний үр удамд өгөх болно хэмээн миний эцгүүдийн Бурхан надад андгайлсан билээ.

8 Тиймийн тул, Ай, хүү минь чамайг би өөртөө үйлчлэгч болгон өсгөхөд өөрийн удам угсааг үхлээс аврахад тэрээр намайг адисалсан бөлгөө;

9 Чиний ахан дүүс миний хүмүүсийг уг нутагт туйлын бэрх байсан өлсгөлөнгөөс чөлөөлөхөд; иймийн тул, тэд чиний ах нараас дээгүүр чиний эцгийн удам угсаанаас дээгүүр адислагдахын тулд чиний эцгүүдийн Бурхан чамайг, мөн чиний хэвлийн үр жимсийг адислах болно.

10 Учир нь чи давамгайлах боллоо, мөн эцгийн чинь удам угсаа чиний өмнө бөхөлзөх боллоо, бүр энэ нь чамайг ах нарынхаа гараар Египетэд худалдагдахаас өмнө чамд үзүүлэгдсэн билээ; тиймийн тул, ах нар чинь чамд, үеэс үед чамд, чиний хэвлийн үр жимсэнд үүрд бөхөлзөх болно;

11 Учир нь тэдний боолчлолын өдрүүдэд тэднийг боолчлолоос чөлөөлөхөд; мөн тэд бүгд хамтдаа нүгэл дор бөхийхөд чи миний хүмүүст гэрэл байх болно.

ИСО, Эхлэл 50:24–38 (Эхлэл 50:24–26-тай харьцуул; мөн 2 Нифай 3-ыг үз)

(Мосе, Аарон түүнчлэн Иосеф Смит Египет дэх Иосефын тухай энэхүү бошиглолд бүгд нэрлэгдсэн байв. Түүнчлэн, Мормоны Ном нь Иудейн цэдгийн хам хэсэг байх болно гэдгийг Иосеф бошигложээ.)

24 Мөн Иосеф ах нартаа хэлсэн нь, би үхэж, мөн эцгүүддээ очно; түүнчлэн би баяр хөөртэйгөөр доош булшиндаа одно. Миний эцэг Иаковын Бурхан, та нарын боолчлолын өдрүүдэд та нарыг гай зовлонгоос чөлөөлөхөд та нартай хамт байх болно; учир нь Их Эзэн над дээр ирж, мөн Их Эзэн Бурхан миний хэвлийгээс, миний хэвлийн үр жимснээс зөв шударга салаа мөчрийг мөн Израил хэмээн миний эцэг Иаковын нэрлэсэн нэгэн бошиглогчийг

(Шило хэмээгддэг Мессиа биш) чамд мөн энэ бошиглогч чиний боолчлолын өдрүүдэд миний хүмүүсийг Египетээс гарган авчрах болно.

25 Мөнхүү улиран тохиох дор тэд дахин тараагдах болно; мөн мөчир нь хугарах болно, бас алс холын оронд аваачигдах болно; гэсэн хэдий ч Мессиаг ирэхэд тэд Их Эзэний гэрээнүүдэд санагдах болно; учир нь тэрбээр хожмын өдрүүдэд хүч чадлын Сүнсэнд тэдэнд үзүүлэгдэх болно; мөн тэднийг харанхуйгаас гэрэлд, мөн боолчлолоос эрх чөлөөнд гарган авчрах болно.

26 Миний хэвлийн үр жимсэнд сонгогдсон үзмэрч байх нэгэн үзмэрчийг миний Бурхан Их Эзэн өсгөн бойжуулах болно,

27 Эцгүүдийн минь Бурхан Их Эзэн ийн надад айлдав, Чиний хэвлийн үрсээс бибээр нэгэн сонгогдсон үзмэрчийг өсгөн бойжуулах болно, мөн тэрбээр чиний хэвлийн үр жимсний дунд ихэд хүндлэгддэг байх болно; мөн тэрбээр чиний хэвлийн үр жимс, өөрийн ахан дүүсийн тулд ажил хийх зарлигийг би түүнд өгөх болно.

28 Мөн тэрээр чиний эцгүүдтэй миний хийсэн гэрээний тухай мэдлэгүүдэд тэднийг авчрах болно; бас тэрээр өөрт нь миний зарлиглах ямар ч ажлыг хийх болно.

29 Мөн би түүнийг өөрийн мэлмийд агуу их болгоно, учир нь тэрээр миний ажлыг хийх болно; мөн Ай Израилын угсаа, бибээр өөрийн хүмүүсийг Египетийн нутгаас чөлөөлөн гаргахын тулд та нарын төлөө өсгөн бойжуулах болно хэмээн миний хэлсэн түүнтэй тэрээр агуу ихээр адилхан байх болно; учир нь өөрийн хүмүүсийг Египетийн нутгаас чөлөөлөн гаргахын тулд би үзмэрчийг өсгөн бойжуулах болно; мөн тэрбээр Мосе хэмээн нэрлэгдэх болно. Мөн энэ нэрээр тэр чиний угсааных гэдгээ мэдэх болно; учир нь тэрээр хааны охиноор асруулж, мөн түүний хүү хэмээн нэрлэгдэх болно.

30 Мөн дахин бибээр чиний хэв-

лийн үр жимснээс үзмэрчийг өсгөн бойжуулах болно, мөн чиний хэвлийн үр удамд миний үгийг урагш авчрах хүчийг би түүнд өгөх болно; мөн зөвхөн миний үгийг урагш авчрах төдийгүй, харин өнгөрсөн үед тэдний дунд аль хэдийнээ урагш ирсэн миний үгэнд тэднийг итгүүлэх хүчийг буюу;

31 Иймийн тулд чиний хэвлийн үр жимс бичих болно, мөн Иудагийн хэвлийн үр жимс бичих болно; мөн чиний хэвлийн үр жимсээр бичигдсэн тэр нь, мөн түүнчлэн Иудагийн хэвлийн үр жимсээр бичигдсэн тэр нь хуурамч сургаалуудыг шившиглэхэд мөн зөрчилдөөнүүдийг намжааж, бас чиний хэвлийн үр жимсний дунд амар амгаланг төлөвшүүлж, мөн хожмын өдрүүд дэх тэдний эцгүүдийн тухай мэдлэгт тэднийг авчрахын тулд хамтдаа өсч хөгжих болно; мөн тэрчлэн миний гэрээнүүдийн тухай мэдлэгт хэмээн Их Эзэн айлдав.

32 Мөн Израилын угсаа болох миний хүмүүсийг эцсийн өдрүүдэд сэргээх миний ажил бүх хүмүүсийн минь дунд урагш гарч ирэх тэр өдөр тэрээр сул доройгоос хүчирхэг болгогдох болно.

33 Мөн тэрхүү үзмэрчийг би адислах болно, мөн түүнийг устгахыг эрэлхийлэх тэд шившиглэгдэх болно; учир нь би чамайг нэг үеэс нөгөө үед санах болно; мөн түүний нэр Иосеф байх болно, бас энэ нь эцгийнх нь нэр байх болно; мөн тэрээр чамтай адилхан байх болно, учир нь түүний гараар Их Эзэн урагш авчрах тэрхүү зүйл миний хүмүүсийг авралд авчрах болно.

34 Мөн Их Эзэн түүний үр удмыг үүрд хамгаалан үлдээх болно хэмээн Иосефт андгайлж, айлдахдаа, бибээр Мосег өсгөн бойжуулах болно, мөн саваа түүний гарт байх болно, мөн тэрээр миний хүмүүсийг хамтад нь цуглуулах болно, мөн тэрээр тэднийг сүрэг мэт удирдан хөтлөх болно, бас тэрээр мөнөөх саваагаараа Улаан Тэнгисийн усыг цохих болно.

35 Мөн шүүлт түүнд байх болно, мөн Их Эзэний үгийг бичих болно. Мөн тэрээр олон үгсийг ярих нь үгүй, учир нь би өөрийн хуулийг өөрийнхөө гарын хуруугаар түүнд бичих болно. Мөн би түүний өмнөөс төлөөлөн яригчийг бий болгоно, мөн түүний нэр Аарон хэмээн дуудагдах болно.

36 Мөн энэ нь бүр миний андгайлсанчлан эцсийн өдрүүдэд чамд үйлдэгдэх болно. Тиймийн тул Бурхан чамд зайлшгүй айлчилж, мөн чамайг энэ нутгаас гарган Абрахамд, мөн Исаакт, бас Иаковт андгайлсан тэр нутагт авчрах болно хэмээн Иосеф ах нартаа хэлэв.

37 Мөн Иосеф бусад олон зүйлийн талаар ах нартаа нотлов, мөн Бурхан та нарт зайлшгүй айлчлах болно, мөн та нар миний ясыг эндээс авч явах болно.

38 Тийнхүү Иосеф нэг зуун арван настайдаа нас нөгчсөн буюу; мөн тэд түүнийг занданшуулж, мөн тэд түүнийг Египетэд авсанд хийжээ; мөн тэрээр дээш гарган зөөгдөж эцэгтэйгээ хамт булшинд тавигдаж болохын тулд Израилын хүүхдүүд түүнийг оршуулганаас нь гарган авсан болой. Мөн ийн тэд түүнд андгайлсан тангаргаа санажээ.

ИСО, ЕГИПЕТЭЭС ГАРСАН НЬ 4:21

(Египетээс Гарсан нь 4:21; 7:3, 13; 9:12; 10:1, 20, 27; 11:10; 14:4, 8, 17; Дэд Хууль 2:30-тай харьцуул)

(Фарао зүрх сэтгэлээ хатууруулсны төлөө Их Эзэн хариуцлага хүлээсэнгүй. Тэрчлэн ИСО Египетээс Гарсан нь 7:3, 13; 9:12; 10:1, 20, 27; 11:10; 14:4, 8, 17-г үз; ишлэл бүр зөв орчуулагдсан тохиолдолд, Фарао зүрх сэтгэлээ өөрөө хатууруулсныг харуулдаг.)

21 Мөн Их Эзэн Мосед хэлсэн нь, Чи Египетэд эргэж очих үедээ чиний гарт миний өгсөн эдгээр бүх гайхалтай зүйлийг Фараогийн өмнө үйлдэхээ мэдэгтүн, мөн би чамайг дэгжүүлэн хөгжүүлэх болно; харин Фарао зүрх сэтгэлээ хатууруулах

болно, мөн тэрээр хүмүүсийг явуулах нь үгүй болгоо.

ИСО, Египетээс Гарсан нь 18:1

(Египетээс Гарсан нь 18:1-тэй харьцуул)

(Иетро дээд санваартан байв.)

1 Мидианы дээд санваартан, Мосегийн хадам эцэг Иетро, Мосегийн төлөө мөн түүний хүмүүс Израилын төлөө Бурханы хийсэн бүхнийг мөн Их Эзэн Израилыг Египетээс гаргасныг сонсох үедээ;

ИСО, Египетээс Гарсан нь 22:18

(Египетээс Гарсан нь 22:18-тай харьцуул)

(Алуурчид амьдрах ёсгүй.)

18 Алуурчин амьд явахыг чи зөвшөөрөх ёсгүй.

Египетээс Гарсан нь 33:20, 23

(Египетээс Гарсан нь 33:20, 23-той харьцуул)

(Нүгэлт хүн Бурханы нүүрийг харж, мөн амьдарч чадах нь үгүй.)

20 Мөн тэрээр Мосед хэлэв, тэрчлэн миний уур чиний эсрэг дүрэлзэж, мөн бибээр чамайг мөн чиний хүмүүсийг устгахгүйн тулд чи энэ цаг үед миний нүүрийг харж чадахгүй; учир нь энэ цаг үед намайг харж мөн амьдрах хүн тэдний дунд үгүй, учир нь тэд үлэмж нүгэлтнүүд билээ. Мөн миний нүүрийг харж мөн амьдрах тийм нүгэлгүй хүн ямар ч үед байгаагүй, мөн тийм нүгэлгүй ямар ч хүн, ямар ч цаг үед байхгүй байх болно.

23 Мөн бибээр гараа татан авах болно, мөн чи миний ар талыг харах болно, харин миний нүүр бусад цаг үеүдийн адил харагдах нь үгүй байх болно; учир нь би өөрийн хүмүүс Израилд ууртай байна.

Египетээс Гарсан нь 34:1–2, 14

(Египетээс Гарсан нь 34:1–2, 14; Сургаал ба Гэрээ 84:21-26-тай харьцуул)

(Мосед өгөгдсөн хоёр дахь чулуун хавтангууд түрүүчийнхээсээ бага хуулийг агуулсан байв.)

1 Мөн Их Эзэн Мосед хэлжээ, чи мөнөөх хоёр чулуун хавтанг түрүүчийнхийн адилаар засаж янзлагтун, мөн хуулийн үгс нь чиний эвдсэн түрүүчийн хавтан дээр бичигдсэн байсны дагуу би тэдгээрийг чулуун хавтангууд дээр тэрчлэн бичих болно; гэвч энэ нь түрүүчийнхийн дагуу байх нь үгүй, учир нь санваарыг би тэдний дундаас авах болно; тиймийн тул, миний ариун жаяг, мөн үүний ёслолууд тэдний өмнө явах нь үгүй; учир нь би тэднийг устгахгүйн тулд миний оршихуй тэдний дунд байх нь үгүй.

2 Гэвч түрүүчийн чулуун хавтан дээрхийн адил хуулийг би тэдэнд өгөх болно, харин энэ нь дэлхийн зарлигуудын хуулийн дагуу байх болно; учир нь тэд тэнэмэл амьдралынхаа өдрүүдэд миний оршихуйд миний амралтад орох нь үгүй хэмээн бибээр хилэгнэлдээ андгайлсан буюу. Тиймийн тул, чамд миний зарлигласны дагуу үйлд, мөн өглөө болоход бэлэн бай, мөн өглөө Синай ууланд хүрч ир, тэгээд уулын орой дээр өөрийгөө надад таниул.

(Иехова бол үүгээр Хуучин Гэрээний хүмүүс Их Эзэн Есүс Христийг мэддэг байсан нэг нэр байв.)

14 Учир нь чи өөр бурханыг бүү шүт: учир нь Иехова нэртэй Их Эзэн бол хартай Бурхан юм.

ИСО, Дэд хууль 10:2 (Дэд хууль 10:2)

(Түрүүчийн чулуун хавтангууд дээр Бурхан ариун санваарын үүрдийн гэрээг илчилсэн байжээ.)

2 Мөн чиний эвдсэн түрүүчийн хавтангууд дээр байсан үгсийг, ариун санваарын үүрдийн гэрээнйхээс бусдыг нь би хавтангууд дээр бичих болно, мөн чи тэдгээрийг авдарт хийх болно.

ИСО, 1 Самуел 16:14-16, 23

(1 Самуел 16:14-16, 23-тай харьцуул; адил өөрчлөлтүүд
1 Самуел 18:10 ба 19:9-д хийгджээ)

(Саул дээр ирсэн муу ёрын сүнс Их Эзэнээс биш байжээ.)

14 Харин Их Эзэний Сүнс Саулаас салж одсон байв, мөн Их Эзэнийх бус байсан муу ёрын сүнс түүнийг зовлонд унагасан ажээ.

15 Мөн Саулын зарц нар түүнд хэлэв, Эдүгээ болгоогтун, Бурханых бус байсан муу ёрын сүнс таныг зовлонд унагасан болой.

16 Ятгаар чадварлаг тоглогч хүнийг хайж олохыг бидний эзэн эдүгээ өөрийнхөө өмнө байгаа зарц нартаа зарлиглаж; мөнхүү улиран тохиох дор Бурханых бус мөнөөх муу ёрын сүнс тань дээр байх үед, тэрээр гараараа тоглох болно, мөн та сайн байх болно.

23 Мөнхүү улиран тохиох дор Бурханых бус байсан мөнөөх муу ёрын сүнс Саул дээр байсан үед, Давид ятга хөгжим авч, мөн өөрийн гараар тоглов; тийнхүү Саул шинэчлэгдсэн байв, мөн сайн байлаа, тийнхүү муу ёрын сүнс түүнээс салж одов.

ИСО, 2 Самуел 12:13 (2 Самуел 12:13-тай харьцуул)

(Давидын харамсалтай нүгэл Бурханаар зайлуулагдсангүй.)

13 Мөн Давид Натанд хэлэв, Их Эзэний эсрэг нүгэл үйлдлээ би. Мөн Натан Давидад хэлэв, Чамайг үхэхгүй байхын тулд Их Эзэн түүнчлэн чиний нүглийг зайлуулсангүй.

ИСО, Шастирын Дэд 18:22
(Шастирын Дэд 18:22-той харьцуул)

(Их Эзэн худал хэлэгч сүнсийг бошиглогчдын аманд хийдэггүй.)

22 Эдүгээ иймийн тул, болгоогтун, Их Эзэн чиний эдгээр бошиглогчдын аманд худал хэлэгч сүнс буйг

олж мэджээ, мөн Их Эзэн чиний хилэнцийг ярилаа.

ИСО, Дуулал 14:1-7 (Дуулал 14:1-7-той харьцуул)

(Дуучин сэргээлтийн өдөрт баясав.)

1 Мунхаг нэгэн зүрх сэтгэлдээ хэлсэн нь, Бурханыг харсан хүн үгүй. Учир юун гэвэл тэрээр өөрийгөө бидэнд харуулдаггүй, тиймийн тул, Бурхан байдаггүй. Болгоогтун, тэд ялзарчээ; тэд жигшүүрт үйлүүдийг үйлдэв, мөн тэднээс нэг нь ч сайныг эс үйлддэг буюу.

2 Учир нь Их Эзэн тэнгэрээс хүмүүний үрс дээр доош харж мөн өөрийн дуу хоолойгоор үйлчлэгчид дээ айлдав, Бурханыг ойлгодог хэн нэгнийг олж харахаар та нар хүмүүний үрсийн дунд эрэгтүн. Мөн тэрээр Их Эзэн өөд амаа нээж хэлэв. Болгоогтун, хэлдэг эдгээр бүгд тэд таных бөлгөө.

3 Их Эзэн хариулж, мөн хэлсэн нь, тэд бүгдээрээ амаас гажсан, тэд хамтдаа бузар булай болсон, сайныг үйлдэгч нэгэн ч үгүй, нэгийг ч чи болгоож чадах нь үгүй бөлгөө.

4 Тэдэнд байгаа бүхэн нь багш нарынхаа хувьд тэд алдсын ажилчид юм, мөн тэдэнд мэдлэг гэж үгүй. Тэд бол миний хүмүүсийг идэж дуусгагчид юм. Тэд талх идэж мөн Их Эзэнийг дуудах нь үгүй.

5 Тэд агуу айдастай байдаг, учир нь Бурхан зөв шударга хүмүүсийн үеийнхэн дотор оршдог. Тэрбээр ядуусын зөвлөгч бөлгөө, учир юун гэвэл тэд ёс бусчуудаас ичдэг, мөн толгой хоргодох газрын тулд Их Эзэн уруу зугтдаг буюу.

6 Тэд ядуугийн зөвлөгөөнөөс ичдэг, учир юун гэвэл Их Эзэн бол түүний толгой хоргодох газар бөлгөө.

7 Ай Израилын аврал, тэрхүү Сион тэнгэрээс байгуулагдсан билээ. Ай Их Эзэн минь та Сионыг хэзээ байгуулах вэ? Их Эзэн өөрийн хүмүүсийн боолчлолыг гэдрэг аваачих үед Иаков баясах болно, Израил баяртай байх болно.

ИСО, Дуулал 24:7–10 (Дуулал 24-тэй харьцуул)

(Энэ дуулал Христийн хоёр дахь ирэлтийг баяр ёслолын байдалтайгаар өгүүлдэг.)

7 Тэргүүнээ өргөгтүн, Ай Иаковын удмынхан та нар, мөн өргөгдөгтүн та нар; мөн Их Эзэн хүчтэй бөгөөд хүчирхэг болгоо; алдар суугийн хаан, тулалдаанд хүчирхэг Их Эзэн та нарыг эгнэгт төлөвшүүлэх болно.

8 Мөн тэрбээр тэнгэрийг хуйлан эвхэх болно, мөн өөрийн хүмүүсийг гэтэлгэхээр; та нарыг үүрдийн нэртэй болгохоор; та нар дээр өөрийн үүрдийн хадгыг үндэслэн байгуулахаар доош бууж ирэх болно.

9 Тэргүүнээ өргөгтүн, Ай Иаковын үеийнхэн та нар; тэргүүнээ өргөгтүн, үүрдийн үеийнхэн та нар, мөн түмний Их Эзэн, хаадын хааных болой;

10 Бүр алдар суугийн хаан та нар хүрч ирэх болно; мөн өөрийн хүмүүсийг гэтэлгэх болно, мөн тэднийг зөв шударга ёсонд төлөвшүүлэх болно. Села

ИСО, Дуулал 109:4 (Дуулал 109:4-тэй харьцуул)

(Бид дайснуудынхаа төлөө залбирах ёстой.)

4 Түүнчлэн, би хэдийгээр хайрладаг ч гэсэн, тэд миний дайснууд билээ; гэвч би тэдний төлөө залбиралд үргэлжлүүлсээр байх болно.

ИСО, Исаиа 42:19–23 (Исаиа 42:19–22-той харьцуул)

(Их Эзэн өөрийн үйлчлэгчийг хараагүйчүүдэд илгээх болно.)

19 Учир нь би өөрийн үйлчлэгчийг хараагүй та нарт илгээх болно; тийм ээ, хараагүйчүүдийн нүдийг нээж, сонсголгүйчүүдийн чихний бөглөөсийг авахаар буюу;

20 Мөн хэрэв тэд Их Эзэний үйлчлэгч элчийг сонсож дагах аваас, хараагүйгээсээ үл хамааран тэд төгс болгогдох болно.

21 Та нар бол олон зүйлийг хардаг

хүмүүс билээ, гэвч ажигладаггүй; та нар сонсохын тулд чихээ нээвч сонсдоггүй билээ.

22 Ийм хүмүүс Их Эзэний таашаалд үл нийцдэг, гэвч түүний зөв шударгын ачаар тэрбээр хуулийг дээдэлж мөн үүнийг хүндэтгэлтэй болгодог.

23 Та нар бол дээрэмдүүлж, мөн эвдэрсэн хүмүүс билээ; дайснууд чинь тэд бүгдээрээ та нарыг нүхэнд урхидан оруулжээ, мөн тэд та нарыг шорон гэрт нуусан ажээ; тэд та нарыг олзонд аваачиж өгдөг буюу, мөн нэг нь ч чөлөөлөгддөггүй; эвдэршийн учир мөн сэргээхэмээн хэн нь ч хэлдэггүй.

ИСО, Иеремиа 26:13 (Иеремиа 26:13-тай харьцуул)

(Их Эзэн наманчилдаггүй; хүмүүн наманчилдаг.)

13 Тиймийн тул эдүгээ, замаа хийгээд үйлүүдээ залруулагтун, мөн Их Эзэн Бурханыхаа дуу хоолойг дуулгавартай дагагтун, мөн наманчил, мөн Их Эзэн та нарын эсрэг зарлан тунхагласан хилэнцийг зайлуулах болно.

ИСО, Амос 7:3 (Амос 7:3-тай харьцуул)

(Их Эзэн наманчилдаггүй; хүмүүс наманчилдаг.)

3 Мөн Их Эзэн Иаковын талаар хэлсэн нь, үүний төлөө Иаков наманчлах ёстой, тиймийн тул, би түүнийг бүрмөсөн устгах нь үгүй хэмээн Их Эзэн айлдав.

ИСО, Матай 3:24–26 (Матай 2:23-тай харьцуул)

(Есүсийн залуу нас хийгээд хүүхэд ахуй үе дүрслэгддэг.)

24 Мөнхүү улиран тохиох дор Есүс дүү нарынхаа хамт өсч, мөн хүчтэй болж, тэгээд Их Эзэний хувьд өөрийн тохинууллын цаг ирэхийг хүлээж байлаа.

25 Мөн тэрээр эцгийнхээ хараан дор үйлчилж байв, мөн тэрээр бусад хүмүүсийн адилаар ярьдаггүй,

мөн тэрээр заалгуулдаг байсан нь ч үгүй; учир нь аль нэгэн хүн түүнд заах ёстой нь түүнд хэрэгтэй байсангүй.

26 Мөн олон жилийн дараа, түүний тохинууллын цаг ойрхон болсон байв.

ИСО, Матай 3:43–46 (Матай 3:15–17-той харьцуул)

(Есүс Иоханаар усанд умбуулалтаар баптисм хүртэв.)

43 Мөн Есүс хариулж, түүнд хэлэхдээ, Танаас баптисм хүртэхийг надад зөвшөөрөх ажаамуу, учир нь энэ нь бүхий л зөв шударгыг биднээр гүйцэлдүүлэх болгодог ажгуу. Тэгээд тэрбээр түүнд зөвшөөрөв.

44 Тэгээд Иохан ус уруу доош орж мөн түүнд баптисм хүртэв.

45 Мөн Есүс, тэрээр баптисм хүртээд уснаас тэр даруй дээш гарч ирэв; мөн тэнгэр түүнд нээгдсэнийг Иохан харж мөн үзэв, мөн Бурханы Сүнс тагтаа хэлбэрээр бууж ирэн Есүс дээр суухыг тэрээр харав.

46 Мөн хартал, энэ бол миний таашалд нийцдэг хайртай Хүү минь, та нар түүнийг анхаарагтун хэмээн тэнгэрээс хэлэх дуу хоолойг тэрээр сонсов.

ИСО, Матай 4:1, 5–6, 8–9 (Матай

4:1, 5–6, 8–9-тэй харьцуул; мөн үүнтэй адил өөрчлөлтүүд Лук 4:2, 5-11-д хийгджээ)

(Есүс Сатанаар биш Сүнсээр хөтлөгдөв.)

1 Тийнхүү Есүс Бурхантай хамт байхаар цөл уруу Сүнсээр хөтлөгдөв.

5 Тэгээд Есүс ариун хотод аваачигдан, мөн Сүнс түүнийг ариун сүмийн орой дээр тавив.

6 Тэгтэл чөтгөр түүн дээр ирж хэлсэн нь, Хэрэв чи Бурханы Хүү юм бол өөрийгөө доош хая: учир нь энэ нь бичигдсэн билээ, Тэрээр чиний талаар санаа тавихыг тэнгэр элчүүддээ үүрэг болгох болно: мөн ямар ч үед чи хөлөөрөө чулуу

өшиглөхгүйн тулд тэд чамайг гар дээрээ авч явах болно.

8 Мөн дахин Есүс Сүнсэн дотор байв, мөн энэ нь түүнийг үлэмж өндөр ууланд аваачиж, тэгээд дэлхийн бүх хаант улсууд хийгээд тэдгээрийн алдар сууг түүнд үзүүлэв.

9 Мөн чөтгөр түүн дээр дахин ирж мөн хэлсэн нь, хэрэв чи доош унаж, мөн намайг шүтэх аваас эдгээр бүх зүйлийг би чамд өгье.

ИСО, Матай 4:11 (Матай 4:11-тэй харьцуул)

(Иохан Баптисмад тохинуулахаар Есүс тэнгэр элчүүдээ илгээв.)

11 Мөн эдүгээ Иохан шоронд хаягдсаныг Есүс мэдэв, мөн тэрээр тэнгэр элчүүдийг илгээв, мөн, болгоогтун, тэд ирж мөн түүнд тохиулав.

ИСО, Матай 4:18 (Матай 4:19-тэй харьцуул)

(Хуучин Гэрээний бошиглогчид Есүсийн тухай өгүүлэв.)

18 Мөн тэрээр тэдэнд хэлсэн нь, Бошиглогчдоор бичигдсэн тэр нь би болой; намайг дагагтун, мөн би та нарыг хүмүүсийн загасчид болгоё.

ИСО, Матай 4:22 (Матай 4:23-тай харьцуул)

(Есүс өөрийнх нь нэрэнд итгэдэг тэдний дундах хүмүүсийг эдгээв.)

22 Мөн Есүс тэдний синагогуудад зааж мөн хаант улсын сайн мэдээг номлон; мөн өөрийнх нь нэрэнд итгэдэг хүмүүсийн дундах бүхий л төрлийн өвчлөл хийгээд бүхий л төрлийн өвчнүүдийг эдгээн бүх Галил даяар явав.

ИСО, Матай 6:14 (Матай 6:13-тай харьцуул; мөн адил төстэй өөрчлөлтүүд Лук 11:4-т хийгджээ)

(Их Эзэн биднийг уруу таталтад хөтөлдөггүй.)

14 Мөн бид уруу таталтад хөтлөг-

дөхийг үл хүлцээч, харин биднийг хилэнцээс чөлөөлөөч.

ИСО, Матай 6:22 (Матай 6:22-той харьцуул)

(Хэрэв бидний мэлмий Бурханы алдар сууд чин үнэнч байх аваас, бидний бүх бие гэрлээр дүүрэх болно.)

22 Биеийн гэрэл нь нүд болой; тиймийн тул хэрэв чиний нүд Бурханы алдар сууд чин үнэнч байх аваас, чиний бүх бие гэрлээр дүүрэх болно.

ИСО, Матай 6:38 (Матай 6:33-тай харьцуул)

(Бид юуны түрүүнд Бурханы хаант улсыг байгуулахыг эрэлхийлэх ёстой.)

38 Иймийн тул, энэ дэлхийн зүйлүүдийг бүү эрэлхийл, харин та нар юуны түрүүнд Бурханы хаант улсыг байгуулахыг, түүнчлэн түүний зөв шударга ёсыг үндэслэн бий болгохыг эрэлхийл, мөн эдгээр бүх зүйл та нар т нэмэгдэх болно.

ИСО, Матай 7:1–2 (Матай 7:1–2-той харьцуул)

(Шударга бусаар бүү шүү.)

1 Эдүгээ хүмүүст тэдний хэлэх ёстой эдгээр үгсийг Есүс дагалдагчиддаа заав.

2 Та нар шүүгдэхгүйн тулд шударга бусаар бүү шүү; харин шударга шүүгч адил шүү.

ИСО, Матай 7:9–11 (Матай 7:6-тай харьцуул)

(Хаант улсын нууцуудыг дэлхийтэй бүү хуваалц.)

9 Наманчлагтун, учир нь тэнгэрийн хаант улс та нарт ойрхон ирээд байна хэмээн та нар хэлж, дэлхий уруу яв.

10 Мөн хаант улсын нууцуудыг та нар өөрсдийнхөө хүрээнд хадгалах ёстой; учир нь ариун зүйлийг нөхдөд өгөх нь зохимжгүй байдаг; мөн гахайнууд тэдгээрийг хөл дороо гишгэлэхгүйн тулд та нар сувднуудаа тэдэнд бүү хаяж өг.

11 Учир нь та нар өөрсдөө үүрч эс чадах зүйлийг дэлхий хүлээн авч чадахгүй; иймийн тул тэд дахин эргэж мөн та нарыг урж тасдахгүйн тулд та нар сувднуудаа тэдэнд бүү өг.

ИСО, Матай 9:18–21 (Энэ бол Бошиглогч Иосеф Смитээр сэргээгдэж, Матай 9:15 болон Матай 9:16-гийн хооронд орсон сэдэв юм.)

(Есүс фарисайчуудын баптисмыг эсэргүүцэв; тэрээр Мосегийн хуулийг өгөв.)

18 Тэгээд фарисайчууд түүнд хэлэв, Яагаад та биднийг бүхэл хуулийг сахьдагийг харсан хэрнээ, биднийг баптисмын маань хамт хүлээн авдаггүй билээ?

19 Гэвч Есүс тэдэнд хэлэв, Та нар хуулийг сахьдаггүй. Хэрэв та нар уг хуулийг сахсан бол, та нар намайг хүлээн авах байсан, учир нь би бол хуулийг өгсөн тэрбээр билээ.

20 Би та нарыг баптисмын тань хамт хүлээн аваагүй, учир юун гэвэл энэ нь та нарт ямар ч ашиггүй.

21 Учир нь шинэ болох тэр зүйл ирэхэд хуучин нь хажуу тийш та-вигдахад бэлэн байдаг.

ИСО, Матай 16:25–26 (Матай 16:24-тэй харьцуул)

(“Есүсийн загалмайг үүрэх” гэсэн хэли нь бурханлиг бус явдлыг үгүйсгэх гэсэн утгатай.)

25 Тийнхүү Есүс шавь нартаа хэлсэн нь, Хэрэв миний араас хэн нэгэн нь ирвэл, тэрээр өөрийгөө үгүйсгэг, мөн загалмайгаа үүрч мөн намайг дага.

26 Мөн эдүгээ загалмайгаа үүрэх хүний хувьд бүхий л бурханлиг бус явдлыг, түүнчлэн дэлхийн тачаангуй сэтгэлийг өөртөө үгүйсгэж мөн миний зарлигуудыг сахих ёстой.

ИСО, Матай 17:10–14 (Матай 17:11–13-тай харьцуул)

(Нэг нь бэлтгэхээр мөн нөгөөх нь сэргээхээр хоёр Елиа ирэх ёстой байв.)

10 Мөн тэгээд хариулж мөн хэлсэн нь, Елиа үнэхээр түрүүлж ирэн бошиглогчдын бичсэнчлэн, мөн бүх зүйлийг сэргээх болно.

11 Түүний талаар бичигдсэн Елиа аль хэдийн ирчихсэн гэдгийг би та нарт мөн дахин хэлье, Болгоогтун, би элчээ илгээх болно, мөн тэрээр миний өмнө замыг бэлтгэх болно; мөн тэд түүнийг мэдээгүй, бас өөрсдийнхөө хүссэнийг түүнд хийсэн билээ.

12 Яг үүн лугаа адил тэрчлэн Хүний Хүү тэднийг хүлцэн тэвчих болно.

13 Харин би та нарт хэлье, Елиа гэж хэн бэ? Болгоогтун, энэ бол өөрийнхөө өмнө замыг бэлтгэхээр миний илгээсэн Елиа мөн.

14 Тэгэхэд Баптисм хүртээгч Иоханы талаар, мөн тэрчлэн энэ нь бошиглогчдоор бичигдсэнчлэн ирэх ёстой өөр нэгний талаар тэрээр тэдэнд ярьсныг шавь нар нь ойлгов.

ИСО, Матай 18:11 (Матай

18:11-тэй харьцуул; түүнчлэн Морунай 8-ыг үз)

(Бага насны хүүхдүүд наманчлах шаардлагагүй.)

11 Учир нь алдагдсан зүйлийг аврахаар мөн нүгэлтнүүдийг наманчлалд дуудахаар Хүний Хүү ирэх ёстой; харин эдгээр бяцхан хүүхдүүд наманчлах шаардлагагүй, мөн би тэднийг аврах болно.

ИСО, Матай 19:13 (Матай

19:13-тай харьцуул)

(Бага насны хүүхдүүд аврагдах болно.)

13 Тэгээд тэрээр гараа тэдэн дээр тавьж, мөн залбирахын тулд бяцхан хүүхдүүдийг түүнд авчрав. Мөн шавь нар нь тэднийг шүүмжилж, ингэх хэрэггүй, учир нь иймүүд нь аврагдах болно гэж Есүс хэлсэн хэмээн өгүүлэв.

ИСО, Матай 21:33 (Матай

21:32-33-тай харьцуул)

(Христэд итгэхээсээ өмнө хүмүүс наманчлах ёстой.)

33 Учир нь тэрээр эхлээд наманчлахаас бусдаар миний талаар санаа тавьдаг Иоханд үл итгэдэг тэрээр, надад итгэж чадахгүй.

ИСО, Матай 21:47–56 (Матай

21:45–46-тай харьцуул)

(Өөрийгөө тулгуурын гол чулуу болохыг Есүс тунхаглав. Сайн мэдээ иудейчүүдэд дараа нь харийнханд санал болгогдсон юм. Есүс эргэж ирэх үед ёс бусчууд устгагдах болно.)

47 Мөн ахлах санваартнууд хийгээд фарисайчууд түүний сургаалт зүйрлэлийг сонсоод тэрээр өөрсдийнх нь тухай ярьсныг ойлгов.

48 Тэгээд тэд өөр хоорондоо ярилцсан нь, Энэхүү агуу хаант улсыг тэрээр ганцаараа эвдэж чадна хэмээн энэ хүн бодож байна уу? Мөн тэд түүнд ууртай байлаа.

49 Тэд түүн дээр гараа далайхыг эрэлхийлсэн боловч тэд цугласан олноос айжээ, учир юун гэвэл цугласан олон түүнийг бошиглогч хэмээн үздэгийг тэд мэдэж байв.

50 Мөн эдүгээ шавь нар нь түүн дээр хүрч ирэхэд Есүс тэдэнд хэлэв, тэдэнд миний ярьсан сургаалт зүйрлэлийн үгст та нар гайхав уу?

51 Үнэнээр би та нарт хэлж байна, би бол чулуу бөгөөд тэдгээр ёс бусчууд намайг эсэргүүцдэг.

52 Би бол булангийн тэргүүн билээ. Эдгээр иудейчүүд над дээр унах болно, мөн эвдрэх болно.

53 Мөн Бурханы хаант улс тэднээс авагдах болно, мөн үүний үр жимсийг урагш авчирсан үндэстэнд өгөгдөх болно; (Харийнханыг хэлж байна.)

54 Иймийн тул, энэ чулуу хэн дээр ч уналаа гэсэн, энэ нь түүнийг нунтаг болгон үйрүүлэх болно.

55 Мөн тиймийн тул, талбайн Эзэн ирэхэд тэдгээр өөдгүй ёс бус хүмүүсийг тэрээр устгах болно, мөн өөрийн талбайг бүр эцсийн өдрүүдэд, өөрсдийнхөө улирлуудад үр жимсийг өөрт нь өгөх өөр тариаланчдад дахин өгөх болно.

56 Дэлхий болон түүний оршин

суугчид болох талбайдаа хаанчлахаар Их Эзэн тэнгэрээс бууж ирэх үед харийнхан ч бас устгагдах ёстой хэмээх өөрсдөд нь түүний ярьсан сургаалт зүйрлэлийг тэгэхэд тэд ойлгожээ.

ИСО, Матай 23:6 (Матай 23:9-тэй харьцуул)

(Тэнгэрт байгаа тэр бол биднийг бүтээгч мөн.)

6 Мөн дэлхий дээр хэнийг ч өөрсдийгөө бүтээгч, эсвээс өөрсдийнхөө Тэнгэрлэг Эцэг хэмээн бүү дууд; учир нь та нарыг бүтээгч хийгээд тэнгэрлэг Эцэг нэг юм, бүр тэнгэрт байдаг тэрээр бөлгөө.

ИСО, Матай 26:22, 24–25 (Матай 26:26–29; ИСО, Марк 14:20–25-тай харьцуул)

(Есүс ариун ёслолыг бий болгов.)

22 Мөн тэднийг хооллож байхад Есүс талх авч үйрүүлээд, мөн үүнийг адисалж, тэгээд шавь нартаа өгч хэлэв, Ав, ид; энэ нь та нарын төлөө төлөөсийг нь би хийсэн миний биеийг төлөөлөн дурсахад байдаг.

24 Учир нь энэ бол миний нэрэнд итгэсэн болгоны төлөө тэдний нүглүүдийн ангижралын төлөө урссан миний шинэ гэрээний цусыг төлөөлөн дурсахад байдаг.

25 Мөн миний хийсэн, өөрсдийн харсан тэдгээр зүйлүүдийг та нар сахьж, мөн миний тухай бүр эцсийг хүртэл гэрчил хэмээх нэг зарлигийг би та нарт өгч байна.

ИСО, Матай 27:3–6 (Матай 27:3–5; Үйлс 1:18-тай харьцуул)

(Иудасын үхэл дүрслэгддэг.)

3 Тэгээд түүнээс урвасан Иудас түүний ялагдсаныг хараад, өөртөө наманчилж, мөн мөнөөх гучин мөнгөн зоосыг ахлах санваартнууд хийгээд ахлагчдад дахин авчраад,

4 Хэлсэн нь, би гэмгүй цуснаас урваж нүгэл үйлдлээ.

5 Мөн тэд түүнд хэлэв, Энэ чинь

бидэнд юуны хамаа байна? Чи үүнийг мэдтүгэй; чиний нүглүүд чам дээр байх учиртай.

6 Тэгээд тэрээр мөнгөн зооснуудыг ариун сүм дотор чулуудчихаад мөн тэндээс гарч, мөн яваад мөн өөрийгөө модноос дүүжлэв. Тэгээд тэр даруй тэрээр доош унаж мөн гэдэс дотор нь цувж тэгээд тэрээр үхэв.

ИСО, Марк 9:3 (Марк 9:4-тэй харьцуул)

(Иохан Баптист Хувиралтын Уулан дээр байв.)

3 Мөн тэнд тэдэн дээр Елиа Мосегийн хамт, эсвээс өөр үгээр Иохан Баптист мөн Мосе хүрч ирэв; мөн тэд Есүстэй ярилцсан ажгуу.

ИСО, Марк 9:40–48 (Марк 9:43–48-тай харьцуул)

(Гэм буруутай гар буюу хөлийг тайрч хаях нь хүнийг буруу тийш хөтөлж болох хэлхээ холбоог үгүй болгохтой харьцуулагджээ.)

40 Гиймийн тул, хэрэв гар чинь чамд гэм бурууг үйлдэх аваас, үүнийг тасдаж хая; эсвээс хэрэв ах буюу дүү чинь чамд гэм бурууг үйлдэж мөн эс гэмшин, мөн эс орхих аваас, тэрээр тусгаарлагдах ёстой. Тамд хоёр гартай очсоноос амьдралд тахир дутуу орох нь чиний хувьд дээр юм.

41 Учир нь хэзээ ч унтаршгүй галд, өт хорхой үхэхгүй, мөн гал нь унтрахгүй тамд чи ах буюу дүүтэйгээ хамт хаягдсанаас, ах буюу дүүгүйгээр амьдралд орох нь чиний хувьд дээр юм.

42 Мөн дахин, хэрэв хөл чинь чамд гэм бурууг үйлдэх аваас, үүнийг тасдаж хая; учир нь түүгээр чиний алхлах туг чинь болох тэрээр, хэрэв тэрээр зөрчилтэй болох аваас, тэрээр тусгаарлагдах ёстой.

43 Хэзээ ч унтаршгүй галд, тамд хоёр хөлтэй хаягдсанаас амьдралд хазгар доголлон орох нь чиний хувьд дээр юм.

44 Тиймийн тул, хүн бүр өөрөө зогсох буюу унаг, мөн бусдын төлөө бус байг; эсвээс бусдад бүү итгэн даатга.

45 Миний Эцэгийг эрэлхийлэгтүн, мөн хэрэв та нар хүлээн авах болно гэдэгт итгэн, итгэлд хүсэх аваас, хүссэн тэр зүйл тань яг цагтаа гүйцэлдэх болно.

46 Мөн чиний төлөө хардаг гэрлийг чамд харуулахын тулд, чамайг харж байхаар томилогдсон тэрээр болох нүд чинь зөрчигч болж мөн чамд гэмийг үйлдэх аваас, түүнийг ухаж хая.

47 Тамын галд хоёр нүдтэй хаягдсанаас Бурханы хаант улсад өрөөсөн нүдтэй орох нь чамд дээр.

48 Өт нь үхэхгүй, мөн гал нь унтрахгүй тамд ах буюу дүүтэйгээ хамт хаягдсанаас, чи өөрөө аврагдах нь чамд дээр.

ИСО, Марк 12:32 (Марк 12:27-той харьцуул)

(Бурхан бол нас барагсдын Бурхан биш, учир юун гэвэл нас барагсдыг тэрээр булшнаас нь босгодог.)

32 Тэрээр тийм учраас нас барагсдын Бурхан биш, харин амьд хүмүүсийн Бурхан билээ; учир нь тэрээр тэднийг булшнаас нь босгодог. Тиймээс та нар ихэд эндүүрдэг.

ИСО, Марк 14:20–25 (Марк

14:22–25; ИСО, Матай 26:22, 24–25)

(Есүс ариун ёслолыг бий болгов.)

20 Мөн тэднийг хооллож байхад, Есүс талх авч мөн адислаад мөн үйрүүлж, мөн тэдэнд өгөөд мөн хэлэв, Үүнийг ав, мөн ид.

21 Болгоогтун, энэ бол та нар миний биеийг төлөөлөн дурсаж үйлдэхийн тулд буюу; учир нь та нар үүнийг олонтаа үйлдэхийн хэрээр та нар өөрсөдтэйгөө миний хамт байсан энэхүү цагийг дурсан санах болно.

22 Мөн тэрээр аяга авч, мөн тэр тэдэнд талархал илэрхийлж, мөн

тэрээр үүнийг тэдэнд өгөв; мөн тэд бүгдээрээ үүнээс уув.

23 Мөн тэрээр тэдэнд хэлэв, энэ бол олны төлөө урссан миний цус, мөн та нарт миний өгсөн шинэ гэрээг дурсах нь болой; учир нь та нар миний тухай бүх дэлхийд гэрчлэх болно.

24 Мөн та нар энэ ёслолыг гүйцэтгэхийн хэрээр та нартай би хамт байж, та нартай хамт энэ аяганаас ууж байсан энэхүү цагт, бүр миний тохинууллын сүүлчийн цагт намайг дурсан санах болно.

25 Үнэнээр би та нарт элж байна, энэ тухай та нар гэрчлэх болно; учир нь би Бурханы хаант улсад үүнийг шинээр уух тэр өдрийг хүртэл та нартай хамт усан үзмийн модны жимснээс дахин уухгүй.

ИСО, Марк 14:36–38 (Марк 14:32–34-тэй харьцуул)

(Гетсеманид, бүр Арванхоёрын зарим нь ч Мессиа болох Есүсийн үүргийг бүрэн ухаарсангүй.)

36 Мөн тэд цэцэрлэг байсан Гетсемани хэмээн нэрлэгддэг нэгэн газарт ирэв; мөн шавь нар нь ихэд гайхан, мөн энэ чинь Мессиа байх гэж үү хэмээн гайхаж, зүрх сэтгэлдээ эргэлзэн, мөн ихэд хүнд байв.

37 Мөн Есүс тэдний зүрх сэтгэлийг мэдэж байсан болохоор, шавь нартаа хэлэв, намайг залбирч байх хооронд энд суугтун та нар!

38 Мөн тэрээр Петр мөн Иаков, мөн Иоханыг өөртэйгөө хамт авч яван тэднийг шүүмжилж, мөн тэдэнд хэлэв, Миний бодгаль бүр үхэлд хүртэл үлэмж гунигтай байна; та нар энд үлдэж мөн харагтун.

ИСО, Марк 16:3–6 (Марк 16:4–7

той харьцуул мөн адил төстэй өөрчлөлтүүд Матай 28:2–8-д хийгджээ; Лук 24:2–4-тэй харьцуул)

(Хоёр тэнгэр элч Аврагчийн булшны дэргэд эмэгтэйчүүдтэй мэндчилэв.)

3 Харин тэд хараад, чулуу холдон

өнхөрснийг тэд үзэв, (учир нь энэ нь нэн том байлаа) мөн урт цагаан өмсгөлөөр хувцасласан хоёр тэнгэр элч үүн дээр сууж байв; мөн тэд айж байлаа.

4 Гэвч тэрхүү тэнгэр элчүүд тэдэнд хэлэв, Бүү ай; Назарын цовдлогдсон Есүсийг та нар эрж байгаа; тэрээр боссон; тэр энд байхгүй, болгоогтун, тэд түүнийг тавьсан уг газарт буюу;

5 Мөн замаараа явж, шавь нарт нь болон Петрт хэлэгтүн, тэрээр та нараас өмнө Галил уруу явна; тэрээр та нарт хэлж байсны адилаар тэнд та нар түүнийг харах болно.

6 Мөн тэд бунханд орж, тэд Есүсийг тавьсан газрыг харав.

ИСО, Лук 1:8 (Лук 1:8-тай харьцуул)

(Иохан Баптистын эцэг Захариа санваартны үүргүүдээ биелүүлж байв.)

8 Мөн түүнийг Бурханы өмнө санваартны албан тушаалаа түүний санваарын дэг жаягаар гүйцэтгэж байхад,

ИСО, Лук 2:46 (Лук 2:46-тай харьцуул)

(Ариун сүмд багш нар Есүсийг сонсож мөн түүнээс асуултууд асууж байв.)

46 Мөнхүү улиран тохиох дор гурван өдрийн дараа тэд түүнийг ариун сүмд багш нарын дунд сууж байхыг нь олж харав, мөн тэд түүнийг сонсож, мөн түүнээс асуултууд асууж байв.

ИСО, Лук 3:4–11 (Лук 3:4–6-тай харьцуул)

(Бошиглолыг гүйцэлдүүлж, нүглүүдийг аван, авралыг авчрахаар, мөн гэрэл байхаар Христ ирэх болно, мөн тэрээр сүр хүчний өдөрт, мөн цаг хугацааны бүрэн байдалд ирэх болно.)

4 Энэ нь бошиглогч Есаиагийн номонд бичигдсэнчлэнгээр; эдгээр нь аглаг буйдад хашгирагч нэгний дуу хоолой буюу, Их Эзэний замыг бэлтгэгтүн та нар, мөн түүний за-

мыг шулуун болго хэмээн өгүүлэх үгс бөлгөө.

5 Учрыг болгоогтун, мөн харагтун, энэ нь бошиглогчдын номонд бичигдсэнчлэн, дэлхийн нүглүүдийг авахаар, мөн үнэн Бурханыг мэддэггүй үндэстнүүдэд авралыг авчрахаар, алдагдсан тэднийг, Израилын хонины хашаа болох тэднийг хамтад нь цуглуулахаар тэрээр ирэх болно.

6 Тийм ээ, бүр цөхрөгсөд хийгээд зовогсдыг; мөн тэрчлэн замыг бэлтгэхээр мөн сайн мэдээг Харийнханд номлохыг боломжтой болгохоор;

7 Мөн харанхуйд, газар дэлхийн хамгийн алслагдсан хэсгүүдэд суугч тэд бүгдэд гэрэл байхаар; нас барагсдаас амилуулалтыг тохиолгон авчрахаар, мөн дээд тэнгэрт өгсөн очиж, Эцэгийн баруун гар талд оршихоор буюу,

8 Цаг хугацааны бүрэн байдлыг, мөн хууль хийгээд гэрчлэл нь лацдагдахыг хүртэл, мөн хаант улсын түлхүүрүүд Эцэгт дахин дээш хүргэгдэх болно;

9 Шударга ёсыг бүгдэд гүйцэтгэхээр; бүгдийн дээрх шүүлтэд доош ирэхээр, мөн бурхангүй тэд бүгдийг өөрсдийнх нь үйлдсэн бурханлиг бус үйлүүдэд итгүүлэхээр болой; мөн энэ бүхэн нь түүний ирэх тэрхүү өдөрт буюу;

10 Учир нь энэ бол сүр хүчний өдөр бөлгөө; тийм ээ, хөндий болгон дүүрэх болно, мөн уул болгон мөн дов толгой болж, бүр намхан болгогдох болно; мөн эвдэрсэн тахийсан нь шулуун болгогдох болно, мөн бартаат зам өөгүй тэгш болгогдоно;

11 Мөн бүх маханбодь Бурханы авралыг үзэх болно.

ИСО, Лук 11:53 (Лук 11:52 той харьцуул)

(Судруудын бүрэн байдал нь мэдлэгийн түлхүүр мөн.)

53 Хуульчид та нарт халаг! Учир нь та нар мэдлэгийн түлхүүр, судруудын бүрэн байдлыг холдуулан аваачсан билээ; та нар хаант улсад

өөрсдөдөө орох нь үгүй; мөн орж байсан тэдэнд та нар саад болсон буюу.

ИСО, Лук 12:9–12 (Лук 12:9–10-тай харьцуул)

(Ариун Сүнсний эсрэг гутаах нь өршөөгдөхгүй байх болно.)

9 Харин намайг хүмүүсийн өмнө үгүйсгэдэг тэрээр Бурханы тэнгэр элчүүдийн өмнө үгүйсгэгдэх болно.

10 Эдүгээ үүнийг тэрээр хэлснийг шавь нар нь мэдэж байв, учир юун гэвэл тэд түүний тухай хилэнцтийг хүмүүсийн өмнө ярьсан байжээ; учир нь тэд түүнийг хүмүүсийн өмнө муу хэлэхээс айсан байв.

11 Мөн тэд өөр хоорондоо хэлэлцэн өгүүлсэн нь, Тэрээр бидний зүрх сэтгэлийг мэддэг, мөн биднийг яллан ярьдаг, мөн бид өршөөгдөхгүй. Харин тэрээр тэдэнд хариулж, мөн тэдэнд хэлэв,

12 Хүний Хүүгийн эсрэг үг хэлэх хэн ч гэсэн, мөн наманчилдаг бол, энэ нь түүнд өршөөгдөх болно; харин Ариун Сүнсний эсрэг гутаадаг түүнд, энэ нь өршөөгдөх нь үгүй.

ИСО, Лук 12:41–57 (Лук 12:38–48 тай харьцуул)

(Бид Их Эзэний ирэлтэд үргэлж бэлэн байх ёстой.)

41 Учир нь болгоогтун, тэрээр шөнийн эхний манаанд ирэх болно, мөн тэрээр тэрчлэн хоёр дахь манаанд ирэх болно, мөн дахин тэрээр гурав дахь манаанд ирэх болно.

42 Мөн үнэнээр би та нарт хэлж байна, энэ нь түүний тухай бичигдсэнчлэн, тэрээр аль хэдийн ирчихсэн; мөн дахин тэрээр хоёр дахь манаанд ирэхэд, түүнийг ирэхэд үүнчлэн үйлдэж байх тэдгээр үйлчлэгчид адислагдсан болой;

43 Учир нь тэдгээр үйлчлэгчдийн Их Эзэн өөрийгөө бэлтгэж, мөн тэднийг хооллохоор доош суулгах болно, мөн урагш гарч ирэн мөн тэдэнд үйлчлэх болно.

44 Мөн эдүгээ та нар үүнийг мэ-

дэж болохын тулд мөн Их Эзэний ирэлт нь шөнийн хулгайч адил гэдгийг мэдэж болохын тулд эдгээр зүйлүүдийг би та нарт үнэнээр хэлж байна.

45 Мөн энэ нь хэрэв тэрээр эд хөрөнгөө харахгүй бол түүний сэрээгүй тэр цагт хулгайч ирж, мөн эд хөрөнгийг нь аваачин, тэдгээрийг нөхдийнхөө дунд хувааж авдаг, өрхийн тэргүүн эр хүнтэй адил юм.

46 Мөн тэд өөр хоорондоо хэлэлцсэн нь, хэрэв өрхийн сайн тэргүүн эр хүн хулгайч ирж болох цагийг мэдэх аваас, тэрээр манаа гаргаж, мөн гэр орноо эвдүүлэн хохирч, мөн эд хөрөнгөө алдах нь үгүй.

47 Мөн тэрээр тэдэнд хэлэв, Үнэнээр би та нарт хэлж байна, гиймийн тул, та нар бас бэлэн байгтун; учир нь Хүний Хүү та нарын бодоогүй цагт ирнэ.

48 Тэгээд Петр, Их Эзэн түүнд хэлэв, та энэхүү сургаалт зүйрлэлийг бидэнд ярив уу, эсвээс бүгдэд үү?

49 Мөн Их Эзэн хэлэв, Их Эзэн өөрийн хүүхдүүдэд бор хоолных нь хувийг зохих цагт нь өгөхийн тулд өөрийн өрхийн захирагчид болгох тэдэнд би ярьж байна.

50 Мөн тэд хэлэв, Тэгвэл итгэлтэй хийгээд ухаалаг үйлчлэгч хэн бэ?

51 Мөн Их Эзэн тэдэнд хэлэв, Энэ бол өөрийн бор хоолны хувийг зохих цагт нь хуваалцахын тулд сэрэмжтэй хардаг тэрхүү үйлчлэгч бөлгөө.

52 Их Эзэн нь түүнийг үүнчлэн үйлдэж буйг тэрээр ирэхдээ олох тэрхүү үйлчлэгч адислагдаг.

53 Тэрээр түүнийг өөртөө байдаг бүхний дээр захирагч болгоно гэдгийг би та нарт үнэнээр хэлж байна.

54 Харин сэрэмжтэй байдаггүй тэрээр муу үйлчлэгч мөн. Хэрэв тэрхүү үйлчлэгч сэрэмжтэй байхгүй аваас, Эзэн минь ирэлтээ хойшлуулжээ хэмээн зүрх сэтгэлдээ хэлэх болно; мөн эрэгтэй үйлчлэгчдийг, мөн эмэгтэй үйлчлэгчдийг жанчиж, тэгээд идэж мөн уун, мөн согтууран хөлчүүрч эхлэх болно.

55 Тэрхүү үйлчлэгчийн Эзэн түү-

ний хүлээж байгаагүй өдөр, мөн тэрээр сэрэмжгүй байгаа цагт ирж, тэгээд түүнийг цавчиж хаях болно, мөн түүний хувийг үл итгэгчдийнхтэй хамт өгөх болно.

56 Мөн Эзэнийхээ тааллыг мэддэг, мөн Эзэнийхээ ирэлтэд бэлтгээгүй, мөн түүний тааллын дагуу үйлдээгүй мөнөөх үйлчлэгч олон удаа ташуурдуулж зодуулах болно.

57 Харин Эзэнийхээ тааллыг мэддэггүй тэрээр ташуурдуулбал зохих зүйлүүдийг хийж, хэдхэн удаа ташуурдуулж зодуулах болно. Учир нь их юм өгөгдсөн хэн ч бай, түүнээс их нь шаардагддаг, мөн Эзэн хэнд ихийг даатгасан байна, хүмүүс түүнээс илүү ихийг хүсдэг буюу.

ИСО, Лук 16:16–23 (Лук

16:16–18-тай харьцуул)

(Баян хүн ба Лазарын тухай сургаалт зүйрлэлийн хам сэдвийг Есүс заргажээ.)

16 Мөн тэд түүнд хэлэв, Бидэнд хууль, мөн бошиглогчид буй; харин энэ хүний тухайд гэвэл бид түүнийг өөрсдийн захирагч байхаар хүлээн авахгүй; учир нь тэрээр өөрийгөө бидний дээрх шүүгч болгосон билээ.

17 Тэгэхэд нь Есүс тэдэнд хэлэв, Хууль хийгээд бошиглогчид миний тухай гэрчилдэг, тийм ээ, мөн бичсэн бүх бошиглогчид, бүр Иоханыг хүртэл эдгээр өдрүүдийн тухай угтан хэлсэн бөлгөө.

18 Тэр цагаас хойш Бурханы хаант улс номлогдож буй, мөн үнэнийг эрэлхийлдэг хүн бүр үүнд шамддаг болой.

19 Хуулийн нэг зүйл биелэгдэхгүй болохоос тэнгэр хийгээд газар алга болох нь илүү хялбар бөлгөө.

20 Мөн юуны учир та нар хуулийг зааж, мөн бичигдсэн зүйлийг үгүйсгэн, та нар бүгдээр гэтэлгэгдэж болохын тулд хуулийг хэрэгжүүлэхээр Эцэгийн илгээсэн түүнийг буруутгадаг юм бэ?

21 Өө тэнэгүүд! Учир нь Бурхан гэж үгүй хэмээн та нар зүрх сэтгэлдээ хэлсэн. Мөн та нар зөв замыг

гажуудуулсан билээ; мөн тэнгэрийн хаант улс та нарын хүчирхийллийг тэвчин хүлцсэн бөлгөө; мөн та нар номхон дөлгөөн хүмүүсийг хавчдаг; мөн та нар хүчирхийлэлдээ хаант улсыг устгахыг эрэлхийлдэг; мөн та нар хаант улсын хүүхдүүдийг хүчээр авдаг болой.

22 Мөн тэд садар самууныг үйлдэгчид байсан хэмээн хэлснийх нь төлөө уурлан түүнийг тэд дахин зүхэв.

23 Харин тэрээр үргэлжлүүлэн хэлсэн нь, Эхнэрээ цааш түлхэж өөр нэгэнтэй гэрлэх хэн ч гэсэн садар самууныг үйлддэг; мөн нөхөр нь цааш түлхсэн түүнтэй гэрлэх хэн боловч садар самууныг үйлддэг. Үнэнээр би та нарт хэлж байна, би та нарыг баян хүнтэй адилтгах болно.

ИСО, Лук 17:21 (Лук 17:20–21-тэй

харьцуул)

(Бурханы хаант улс аль хэдийн ирсэн.)

21 Хар ийшээ, эсвээс Хар тийшээ хэмээн тэд хэлэх болно! Учир нь болгоогтун, Бурханы хаант улс та нарт аль хэдийн ирчихсэн билээ.

ИСО, Лук 17:36–40 (Лук 17:37-той

харьцуул)

(Зөв шударга хүмүүсийн цугларалтын тухай сургаалт зүйрлэлийг Есүс тайлбарлав.)

36 Мөн тэд хариулж мөн түүнд хэлсэн нь, Их Эзэн, тэдгээр нь хаанаас авагдах ёстой вэ?

37 Мөн тэрээр тэдэнд хэлсэн нь, Бүрэлдэхүүн хаана ч цугларлаа гэсэн; эсвээс өөр үгээр, гэгээнтнүүд хаана ч цугларлаа гэсэн бүргэдүүд тэнд хамтдаа цугларах болно; эсвээс үлдэгсэд нь тэнд хамтдаа цугларах болно.

38 Тэрээр өөрийн гэгээнтнүүдийн цугларалтыг илэрхийлэн үүнийг мөн бууж ирэн үлдэгсдийг тэдэнд цуглуулах тэнгэр элчүүдийн тухай яриу; нэгнийг нь орноос нь, нөгөөг нь ажлаас нь, өөр нэгнийг талбайгаас хаанаас ч гэсэн цуглуулна.

39 Учир нь үнэхээр тэнд шинэ тэнгэр, мөн зөв шуударга ёс ноёрхсон шинэ дэлхий байх болно.

40 Мөн тэнд цэвэр бус зүйл байхгүй байх болно; учир нь газар дэлхий бүр өмсгөлийн адил хуучирч, ялзалд идэгдэн, иймээс энэ нь алга болж, мөн хөлийн гишгүүр ариусгагдан, бүх нүглээс цэвэрших болно.

ИСО, Лук 18:27 (Лук 18:27-той харьцуул)

(Баялгуудад найдах нь хүнийг Бурханы хаант улсад орохоос нь зайлуулдаг.)

27 Мөн тэрээр тэдэнд хэлэв, Баялгуудад найддаг тэдний хувьд Бурханы хаант улсад орох нь боломжгүй юм; харин энэ дэлхийн зүйлүүдийг орхидог түүнд Бурхантай хамт байх нь боломжтой юм, ингэснээр тэрээр үүнд орох ёстой.

ИСО, Лук 21:24–26 (Лук 21:24–26-тай харьцуул)

(Есүс өөрийн ирэлтийн тэмдгүүдийг тайлбарлав.)

24 Эдүгээ Иерусалимын устгалын талаар тэрээр эдгээр зүйлүүдийг тэдэнд яриу. Мөн дараа нь шавь нар нь түүнээс асууж хэлсэн нь, Эзээн, өөрийнхөө ирэлтийн талаар бидэнд яриач?

25 Мөн тэрээр тэдэнд хариулж мөн хэлэв, Харийнханы цаг гүйцэлдэх тэр үеийнхэнд наранд, мөн саранд, бас однуудад тэмдгүүд байх болно; мөн дэлхий дээр үндэстнүүд далай тэнгис хийгээд хүрхрэх долгион лугаа адил үймэн сандарч, уй гашууд автах болно. Газар дэлхий бас агуу гүний их ус тэрчлэн зовлонд учрах болно;

26 Хүмүүний зүрх сэтгэл айдсын улмаас тэд итгэлгүй болж мөн газар дэлхий дээр ирэх гэж буй зүйлүүдийг хүлээж байлаа. Учир нь тэнгэрийн хүчнүүд сэгсрэгдэх болно.

ИСО, Лук 21:32 (Лук 21:32-той харьцуул)

(Харийнханы цаг гүйцэлдэх үед бүгд гүйцэлдэх болно.)

32 Үнэнээр би та нарт хэлж байна, энэ үеийнхэн, уг үеийнхэн харийнханы цаг гүйцэлдэх үед бүгд гүйцэлдэх хүртэл алга болох нь үгүй.

ИСО, Лук 23:35 (Лук 23:24-тэй харьцуул)

(Есүс өөрийг нь цовдолсон Ромын цэргүүдэд өршөөлийг гуйв.)

35 Тийнхүү Есүс хэлсэн нь, Аав аа, тэднийг өршөөгөөрэй; учир нь тэд өөрсдийнхөө юу хийж байгааг мэдэхгүй байна, (өөрийг нь цовдолсон цэргүүдийг хэлж байна) мөн тэд түүний хувцсыг хувааж авч мөн шодолцов.

ИСО, ИОХАН 1:1–34 (Иохан 1:1–34 тэй харьцуул)

(Есүс Христийн сайн мэдээ эхлэлээс номлогдож байгаа билээ. Нэг Елиа [Иохан Баптист] Христийн замыг бэлтгэх ёстой байв, мөн өөр нэг Елиа [Христ] бүх зүйлийг сэргээх ёстой байв.)

1 Эхлэлд сайн мэдээ Хүүгээр дамжин номлогдож байв. Мөн сайн мэдээ нь үг байв, мөн үг нь Хүүтэй хамт байсан бөлгөө, мөн Хүү Бурхантай хамт байв, мөн Хүү Бурханых байв.

2 Мөнхүү энэ нь эхлэлд Бурхантай хамт байв.

3 Бүх зүйл түүгээр хийгдсэн байв; мөн хийгдсэн зүйлүүдийн аль нь ч түүнгүйгээр хийгдээгүй билээ.

4 Түүнд сайн мэдээ байв, мөн сайн мэдээ нь амьдрал байв, мөн амьдрал нь хүмүүний гэрэл байв;

5 Мөн гэрэл нь дэлхийд гэрэлтдэг, тэгвч дэлхий үүнийг хүлээж аваагүй болой.

6 Нэр нь Иохан байсан, Бурханаас илгээгдсэн нэг хүн байв.

7 Гэрчийн тулд, гэрлийг гэрчлэхээр түүгээр дамжуулан хүмүүн итгэж болохын тулд Хүүгээр дамжуулан сайн мэдээг гэрчлэхээр мөн тийм нэгэн нь дэлхийд ирсэн билээ.

8 Тэрээр тэрхүү гэрэл биш байлаа, гэвч уг гэрлийг гэрчлэхээр иржээ.

9 Тэр нь дэлхийд ирдэг хүн болгоныг гэрэлтүүлдэг үнэн гэрэл байлаа; 10 Бүр Бурханы Хүү буюу. Дэлхийд байсан тэрээр, мөн дэлхий түүгээр хийгдсэн байлаа, мөн дэлхий түүнийг мэдсэнгүй.

11 Тэрээр өөрийнхөндөө ирсэн юм, мөн өөрийнхөн нь түүнийг хүлээн авсангүй.

12 Гэвч түүнийг хүлээн авсан болгонд Бурханы хүүхдүүд болох хүчийг тэрээр тэдэнд, зөвхөн өөрийнх нь нэрэнд итгэдэг тэдэнд өгсөн билээ.

13 Тэрээр цуснаас биш, мөн маханбодийн хүсэл зоригоос, хүмүүний хүсэл зоригоос бус, харин Бурханаас төрсөн юм.

14 Мөн адил үг маханбодь болсон буюу, мөн бидний дунд оршдог байв, мөн бид түүний алдар сууг болгоодог байв, Эцэгийн Төрсөн Ганцынх болох тэрхүү алдар суу нигүүлсэл хийгээд үнэнээр дүүрэн юм.

15 Иохан түүний тухай гэрчилж мөн хашгиран хэлсэн нь, Энэ бол миний ярьсан мөнөөх тэр мөн; Миний араас ирэх тэр, надаас өмнө бэлтгэгдсэн буюу; учир нь тэр надаас өмнө байсан юм.

16 Учир нь эхлэлд Үг байв, бүр маханбодиор хийгдэж, Эцэгийн тааллаар бидэнд илгээгдсэн Хүү буюу. Мөн түүний нэрэнд итгэдэг болгон нь түүний бүрэн байдлыг хүлээн авах болно. Мөн түүний ач ивээлээр дамжуулан бид түүний бүрэн байдлаас, бүр үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүлээн авсан билээ.

17 Учир нь Мосегоор дамжин хууль өгөгдсөн хэдий ч, амьдрал ба үнэн нь Есүс Христээр дамжин ирсэн бөлгөө.

18 Учир нь хууль ердийн зарлигийн маягаар үхлийн гүйцэтгэлд байв; харин сайн мэдээ нь Эцэгийн цээжинд байдаг Төрсөн Ганц Хүү; Есүс Христээр дамжин төгсгөлгүй амьдралын маягаар байв.

19 Мөн тэрээр Хүүгийн тухай гэрчилснээс бусдаар хүмүүн ямар ч үед Бурханыг үзсэн нь үгүй; учир

нь түүгээр дамжихаас бусдаар хүмүүн аврагдаж чадах нь үгүй.

20 Мөн энэ нь Та хэн бэ? хэмээн асуухаар, иудейчүүд санваартнуудыг мөн левичүүдийг Иерусалемаас илгээсэн үе дэх Иоханы цэдэг бөлгөө.

21 Мөн тэрээр хүлээн зөвшөөрч, мөн тэрээр Елиа байсан гэдгийг үгүйсгээгүй билээ; гэвч хүлээн зөвшөөрч хэлсэн нь: Би бол Христ биш.

22 Мөн тэд түүнээс асууж, хэлсэн нь: Та тэгвэл яаж Елиа байх юм бэ? Мөн тэрээр хэлэв, Бүх зүйлийг сэргээх ёстой тэр Елиа би биш. Мөн тэд түүнээс асууж, хэлсэн нь, Та тэр бошиглогч мөн үү? Мөн тэрээр хариулав, Үгүй.

23 Тэгээд тэд түүнд хэлэв, Биднийг илгээсэн тэдэнд бид хариуг өгч болохын тулд Та хэн бэ? Та өөрийнхөө тухай юу хэлэх вэ?

24 Тэрээр хэлсэн нь, Би бол Бошиглогч Есаиасын хэлсэнчлэн Их Эзэний замыг шулуун болгох аглаг буйдад хашгирагч нэгний дуу хоолой.

25 Мөн илгээгдсэн тэд нь фарисайчуудаас байв.

26 Мөн тэд түүнээс асууж, мөн түүнд хэлэв; Хэрэв та Христ биш, бүх зүйлийг сэргээх ёстой Елиа ч биш, мөн тэрхүү бошиглогч ч биш юм бол, тэгвэл та яагаад баптисм хүртээдэг юм бэ?

27 Иохан тэдэнд хариулж хэлсэн нь; Би усаар баптисм хүртээдэг, харин та нарын мэддэггүй нэгэн та нарын дунд зогсож буй;

28 Энэ бол өөрийнх нь тухай миний гэрчилдэг тэр мөн; Тэр бол мөнөөх бошиглогч, бүр миний дараа ирэх Елиа, надаас өмнө бэлтгэгдсэн буюу, би бол түүний гутлын үдээсийг тайлах нь ч зохистой биш, эсвээс байрыг нь би орлож үл чадах буюу;

29 Дараагийн өдөр нь Иохан өөр уруу нь хүрч ирсэн Есүстэй уулзаж, мөн хэлэв; Дэлхийн нүглийг зайлуулах Бурханы Хургыг болгоогтун!

30 Мөн Иохан түүний тухай хүмүүст гэрчлэн хэлсэн нь; Энэ бол

надаас өмнө бэлтгэгдсэн нэг хүн миний дараа ирнэ хэмээн миний ярьсан тэрээр, учир нь тэрээр миний өмнө байсан юм, мөн би түүнийг мэддэг байв, мөн тэрээр Израилд тунхаглагдах ёстой; тиймээс би усаар баптисм хүртээхээр ирсэн билээ.

31 Мөн Иохан гэрчилж, хэлсэн нь; Тэрээр надаас баптисм хүртэх үед Сүнс тагтаа хэлбэрээр бууж ирэн мөн түүн дээр суухыг би харсан.

32 Мөн би түүнийг мэддэг байв; учир нь усаар баптисм хүртээхээр намайг илгээсэн тэрээр, мөнхүү тэрээр надад хэлэв; Сүнс үүн дээр бууж ирэн мөн түүн дээр үлдэхийг чи харна, мөнхүү тэр нь Ариун Сүнсээр баптисм хүртээдэг тэрбээр бөлгөө.

33 Мөн энэ нь Бурханы Хүү мөн гэдгийг харж бас гэрчлэв.

34 Эдгээр зүйлүүд Иохан баптисм хүртээж байсан Иорданы цаадах Бетабарад болсон бөлгөө.

ИСО, Иохан 1:42 (Иохан 1:42-той харьцуул)

(Сефас нь “үзмэрч” буюу “чулуу” гэсэн утгатай.)

42 Мөн тэрээр түүнийг Есүс дээр авчрав. Мөн Есүс түүнийг болгооход, тэрээр хэлэв, Чи бол Ионагийн хүү Симон, чи Сефас хэмээн, орчуулгаар бол үзмэрч буюу чулуу гэж нэрлэгдэх болно. Мөн тэд загасчид байв. Мөн тэд бүгдээрээ тэр даруйд явж, мөн Есүсийг дагав.

ИСО, Иохан 4:1–4 (Иохан 4:1–2-той харьцуул)

(Есүс баптисмууд гүйцэтгэв.)

1 Тиймээс Есүс Иоханаас илүү олон шавьтай болж мөн баптисм хүртээснийг фарисайчууд сонсоод,

2 Тэд түүнийг үхэлд хүргэж болохын тулд зарим аргыг илүү хичээнгүйлэн эрэлхийлж байв; учир нь олон нь Иоханыг бошиглогч хэмээн хүлээн авсан хэдий ч, тэд Есүст итгэхгүй байв.

3 Эдүгээ Их Эзэн үүнийг мэдэж байв, гэсэн хэдий ч өөрийн олон шавь нарын адил тэрээр өөрөө баптисм хүртээсэнгүй;

4 Учир нь тэрээр үлгэр дуурайлын тул, нэг нэгнээ илүүтэй эрхэмлэн тэднийг хүлцэн тэвчиж байв.

ИСО, Иохан 4:26 (Иохан 4:24-тэй харьцуул)

(Бурхан өөрийн Сүнсийг үнэн итгэгчдэд амласан билээ.)

26 Учир нь ийм хүмүүст Бурхан өөрийн Сүнсийг амласан бөлгөө. Мөн түүнийг шүтэн биширдэг тэд, сүнсэнд хийгээд үнэнд шүтэн бишрэх ёстой.

ИСО, Иохан 13:8–10 (Иохан 13:8–10-тай харьцуул)

(Есүс Төлөөлөгчдийн хөлийг угаав)

8 Петр түүнд хэлэв, Та миний хөлийг угаах хэрэггүй. Есүс түүнд хариулав, Хэрэв би чамайг угаахгүй аваас, чи миний нэг хэсэг байх нь үгүй.

9 Симон Петр, Их Эзээн, зөвхөн хөлийг минь төдийгүй, бас тэрчлэн гар мөн толгойг минь хэмээн түүнд хэлэв.

10 Есүс түүнд хэлэв, Түүний гар мөн толгойг угаасан тэрээр хөлийг нь угаахаас зайлсхийх хэрэггүй, харин юм бүхэн нь цэвэрхэн болно; мөн бүгдээрээ биш ч гэсэн, та нар цэвэрхэн билээ. Эдүгээ энэ нь иудейчүүдийн хуулин доорх тэдний заншил байв; ийм болохоор, уг хууль гүйцэлдэж болохын тулд Есүс үүнийг хийв.

ИСО, Иохан 14:30 (Иохан 14:30-тай харьцуул)

(Харанхуйн хунтайж, эсвээс Сатан энэ дэлхийнх билээ.)

30 Үүнээс хойш би та нартай ихийг ярих нь үгүй; учир нь энэ дэлхийнх болох харанхуйн хунтайж ирсэн боловч миний дээр хүчгүй, харин тэрээр та нарын дээр хүчтэй билээ.

ИСО, Үйлс 9:7 (Үйлс 9:7; Үйлс 22:9-тэй харьцуул)

(Паултай хамт түүний хөрвүүлгийн үед байгсад гэрлийг харав, гэвч тэд Их Эзэнийг харсангүй, мөн дуу хоолойг нь сонссонгүй.)

7 Мөн түүнтэй хамт явж байсан тэд үнэхээр гэрлийг харж, мөн айсан байлаа; харин тэд түүнтэй ярьсан хүний дуу хоолойг сонссонгүй.

ИСО, Ром 4:16 (Ром 4:16-тай харьцуул)

(Ач ивээлээр дамжин ирэх итгэл, ажил үйлс хоёулаа авралд шаардлагатай.)

16 Тиймийн тул та нар ач ивээлээр дамжин итгэл хийгээд ажлуудаар зөвтгөгддөг, төгсгөл хүртэл амлалт нь бүх үр удамд бат ноттой байж болно; гагцхүү хуулийнх болох тэдэнд үгүй болой, харин бид бүгдийн эцэг Абрахамын итгэлийнх болох тэдэнд бас тэрчлэн,

ИСО, Ром 7:5–27 (Ром 7:5–25-тай харьцуул)

(Хүмүүний бодгалийг өөрчлөх хүч Христэд буй.)

5 Учир нь биднийг маханбодид байхад хуулийн дагуу биш байсан нүглийн хөдөлгөөн үр жимсийг урагш үхэлд авчрахаар манай гишүүдэд нөлөөлсөн байлаа.

6 Харин эдүгээ уг хуульд бид үхмэл болж, дотор нь баригдаж байсан хуулиас бид чөлөөлөгдлөө, ингэснээр бид сүнсний шинэ байдалд үйлчлэх ёстой, мөн үгсийн хуучин байдалд үгүй болой.

7 Тэгвэл бид юу хэлэх ёстой вэ? Хууль нь нүгэл үү? Бурхан хориглосон юм. Үгүй, би нүглийг мэдэхгүй байв, харин хуулиар буюу; учир нь чи шунах ёсгүй хэмээн хуулийн хэлснээс бусдаар би тачаангуйг мэддэггүй.

8 Харин нүгэл нь зарлигаар тохиолдуулан надад бүхий л төрлийн тачаал шуналыг бий болгожээ. Учир нь хуульгүйгээр нүгэл үхмэл болсон байв.

9 Учир нь нэгэнтээ би хуулийг зөрчилгүйгээр амьд байв, гэвч Христийн зарлиг ирэхэд нүгэл сэр гэж мөн би үхэв.

10 Мөн амьдралд томилогдсон Христийн ирсэн тэрхүү зарлигт намайг итгэхгүй байхад би өөрийгөө үхэлд ялагдсаныг мэдэв.

11 Учир нь нүгэл далимыг ашиглан зарлигийг үгүйсгэж, мөн намайг хуурсан ажээ; мөн үүгээр би алагдсан байлаа.

12 Гэсэн хэдий ч, хууль нь ариун болохыг мөн зарлиг нь ариун, шударга, түүнчлэн сайн болохыг би мэдсэн бөлгөө:

13 Тэгвэл сайн зүйл намайг үхэлд хүргэсэн хэрэг үү? Бурхан хориглосон юм. Гэвч сайн болох зүйлээр ирж болох нүгэл нь надад үхлийг боловсруулсан буюу тэрхүү нүгэл нь зарлигаар үлэмж нүгэлтэй болж болох ажгуу.

14 Учир нь уг зарлиг сүнслэг гэдгийг бид мэддэг; харин намайг хуулин дор байхад, би эгэл хэвээр байж, нүгэл дор худалдагддаг.

15 Харин эдүгээ би сүнслэг байна; учир нь намайг хий хэмээн надад зарлигласныг би хийдэг; мөн үл зөвшөөрөхийг надад зарлигласан зүйлийг би зөвшөөрдөггүй.

16 Учир нь миний мэдэж байгаа зүйл зөв биш бол би зөвшөөрөхгүй; учир нь нүгэл болох зүйлийг би үзэн яддаг.

17 Хэрэв тийнхүү би өөрийн зөвшөөрдөггүй зүйлийг хийдэггүй, сайн болох хуулийг би зөвшөөрдөг; мөн би буруутгагдах нь үгүй болой.

18 Тийнхүү эдүгээ би дахин нүгэл үйлдэхгүй билээ; харин миний дотор орших тэрхүү нүглийг захирахыг би эрэлхийлдэг.

19 Учир нь би өөрийнхөө дотор миний махан бодид сайн биш зүйл оршдогийг мэддэг; учир нь хүсэх нь надтай хамт байдаг, харин сайн болох тэр зүйлийг гүйцэтгэхийг гагцхүү Христэд биш бол би олдоггүй.

20 Учир нь хуулийн дор байхдаа би сайныг үйлдэж болох байв, сайн

байхыг би мэдсэнгүй; тиймээс би үүнийг хийдэггүй.

21 Гэвч хуулийн дор миний үйлдэх учиргүй тэрхүү хилэнц, сайн байхыг нь би эс олов; тиймийн тул, би үүнийг үйлддэггүй.

22 Эдүгээ хэрэв би үүнийг Христийн тусламжаар дамжуулан хийх аваас би хуулийн дор хийх нь үгүй болой. Би хуулийн дор байхгүй байна. Мөн цаашид би бурууг эрэлхийлэх нь үгүй, харин өөрийн дотор орших нүглийг захирах буюу.

23 Тийнхүү хуулийн дор намайг сайныг хийхэд хилэнцэт нь надтай хамт байсныг би мэдсэн; учир нь би өөрийн доторх хүний маягаар Бурханы хуулинд баярладаг.

24 Мөн эдүгээ би өөр хуулийг, бүр Христийн зарлигийг харж байна, мөн энэ нь миний оюунд хэвлэгдсэн билээ.

25 Харин миний гишүүд миний оюуны хуулийн эсрэг дайтаж, мөн миний гишүүдэд байдаг нүглийн хуулийн боолчлолд намайг аваачиж байна.

26 Мөн хэрэв өөрийн дотор байдаг нүглийг би захирахгүй бол, махан-бодиороо нүглийн хуулинд үйлчилнэ; Ай, энэ үхлийн биенээс өөрийгөө чөлөөлөх золгүй хүн юм даа би?

27 Бидний Их Эзэн Есүс Христээр дамжуулан би Бурханд талархаж байна, тийнхүү би өөрийн оюунаар Бурханы хуулинд үйлчилнэ.

ИСО, Ром 8:8 (Ром 8:8-тай харьцуул)

(Махан биеийн замуудыг дагадаг хүмүүс Бурханыг баярлуулж чадахгүй.)

8 Ийнхүү махан биеийг дагадаг тэд Бурханыг баярлуулж чадахгүй.

ИСО, 1 Коринт 7:1–2, 5, 26, 29–33
(1 Коринт 7:1–2, 5, 26, 29–33)

(Номлолд дуудагдсан хүмүүсийн дундах гэрлэлтийн талаарх асуултуудад Паул хариулав.)

1 Эдүгээ, эрэгтэй хүн эмэгтэй хүнд хүрэхгүй байх нь сайн уу? хэ-

мээн өгүүлж, та нараас надад бичсэн тэдгээр зүйлүүдийн тухайд.

2 Гэсэн хэдий ч, завхайрлаас зайлсхийхийн тулд эр хүн болгон өөрийн эхнэртэй байг, мөн эмэгтэй хүн бүр өөрийн нөхөртэй байг хэмээн би хэлж байна.

5 Та нар өөрсдийгөө мацаг хийгээд залбиралд зориулж болохын тулд энэ нь цаг үетэй нийцэж байхаас бусдаар та нар нэг нь нөгөөгөөсөө бүү сал; мөн гэвчишгүй байдлын чинь тулд Сатан та нарыг уруу таахгүйн тулд дахин хамтдаа бай.

26 Тиймээс энэ нь одоогийн зовлонгийн тухайд сайн гэж би бодож байна, учир нь тэрээр илүү сайныг хийж болохын тулд эр хүн иймээр үлдэх буюу.

29 Гэвч тохинуулалд дуудагдсан та нарт би ярьж байна. Үүний тулд, ах нар минь, тохинуулалд та нарын урагш илгээгдэхэд үлдээд байгаа цаг богинохон байна гэдгийг би хэлнэ. Бүр эхнэртэй тэд эхнэргүй мэт байх болно; учир нь та нар Их Эзэний ажлыг хийхээр дуудагдаж мөн сонгогдсон билээ.

30 Хэдийгээр тэд уйлсан ч гэсэн уйлаагүй мэт, мөн тэд баяссан ч гэсэн баясаагүй мэт, мөн тэд худалдаж авсан ч, эзэмшээгүй мэт байх нь тэдэнд байх болно.

31 Мөн энэ дэлхийг ашигладаг тэдэнд үүнийг ашиглаагүй мэт байх болно; учир нь энэ дэлхийн хэв маяг алга болно.

32 Гэвч ах нар минь та нарыг дуудлагаа хичээнгүйлэн гүйцэтгээсэй хэмээнэ би. Та нарыг хайрамжгүй биш байгаасай хэмээнэ би. Гэрлээгүй түүний хувьд бол Их Эзэнд хамаарах зүйлст хийгээд Их Эзэнийг хэрхэн баярлуулж болох тухайд санаа тавьдаг; Тиймээс тэрээр давуу болой.

33 Харин гэрлэсэн тэрээр эхнэрээ хэрхэн баярлуулж болохын тулд дэлхийнх болох тэр зүйлүүдийн төлөө санаа тавьдаг; тиймээс энд ялгаа буй; учир нь тэрээр саатуулагдсан байдаг.

ИСО, 1 Коринт 15:40 (1 Коринт 15:40-тэй харьцуул)

(Ами.луулалтад алдар суугийн гурван зэрэглэл буй.)

40 Тэрчлэн селестиел биес, мөн террестриел биес, мөн телестиел биес; гэвч селестиел алдар суу нь нэг; мөн террестриел нь өөр; мөн селестиел нь өөр.

ИСО, 2 Коринт 5:16 (2 Коринт 5:16-тай харьцуул)

(Маханбодийн маягаар амьдрахгүй байхыг Паул Гэгээнтнүүдэд зөвлөв.)

16 Иймээс нэгэн цагт бид маханбодийн маягаар амьдарч байсан хэдий ч, тийм ээ, үүнээс хойш бид маханбодийн маягаар амьдрах нь үгүй; учир юун гэвэл бид Христийг таньж мэдсэн билээ, эдүгээ үүнээс хойш бид маханбодийн маягаар амьдрах нь үгүй.

ИСО, Галат 3:19–20 (Галат 3:19–20-той харьцуул.)

(Христ бол шинэ гэрээний зууч мөн. Мосегийн хууль [хуучин гэрээ] болон үүрдийн сайн мэдээ [шинэ гэрээ] харьцуулагддаг.)

19 Энэхүү гэрээний (уг хуулийн) зууч байхаар тэнгэр элчүүдийн гараар томилогдсон Мосед өгөгдсөн хуулиар амлалт өгөгдсөн түүнд үр удам ирэх хүртэл зөрчлүүдийн улмаас уг хууль нэмэгдсэн билээ.

20 Эдүгээ энэ зууч нь шинэ гэрээний зууч байгаагүй юм; харин шинэ гэрээний зууч буй, Абрахам болон түүний үр удамд хийгдсэн амлалтуудын талаарх хуулинд бичигдсэнчлэн энэ нь Христ бөлгөө. Эдүгээ Христ бол амьдралын зууч билээ; учир нь энэ бол Бурханаас Абрахамд хийсэн амлалт юм.

ИСО, Ефес 4:26 (Ефес 4:26-тай харьцуул)

(Шударга бус уур бол нүгэл мөн.)

26 Та нар нүгэл үйлдэхгүйгээр ууртай байж чадах уу? Та нарын хи-

лэгнэл дээр нар доош ирэхэд бүү хүргэ;

ИСО, 1 Тесалоник 4:15

(1 Тесалоник 4:15-тай харьцуул)

(Их Эзэний ирэлтийн үед амьд байх зөв шударга хүмүүс нас барсан зөв шударга хүмүүсээс давуу талгүй байх болно.)

15 Учир нь Их Эзэний ирэлтэд амьд байх тэд Их Эзэний ирэлтэд нойрссон байх тэднийг үлдэхэд саад болохгүйн тулд Их Эзэний үгээр бид та нарт үүнийг ярьж байна.

ИСО, 2 Тесалоник 2:2–3, 7–9

(2 Тесалоник 2:2–9-тэй харьцуул)

(Их Эзэн эргэж ирэхээс өмнө тохиох урвалтыг Паул бошигложээ.)

2 Та нар биднээс хүлээн авахаас бусдаар бол, Христийн өдөр ойрхон байна хэмээн сүнсээр ч, мөн үгээр ч, оюун ухаандаа сэгсрэгдэх нь үгүй, эсвээс захидлаар тоогүй байдалд орох нь ч үгүй болой;

3 Хүмүүн аливаа аргаар та нарыг бүү мэхлэг; учир нь эхлээд уналт холдон одох болно; мөн нүгэлт тэр хүн мөхлийн хүү илчлэгдэх болно.

7 Учир нь алдсын нууц аль хэдийн ажиллажээ, мөн эдүгээ ажиллаж буй энэ нь тэр билээ, мөн тэрээр замаас авагдах тэрхүү цаг гүйцэлдэх хүртэл Христ түүний ажиллахыг хүлцэн тэвчих бөлгөө.

8 Мөн тэгээд Их Эзэн түүнийг амныхаа сүнсээр залгиж мөн өөрийнхөө ирэлтийн хурц гэрлээр устгах тэрхүү ёс бус нэгэн илчлэгдэх болно.

9 Тийм ээ, Сатан бүх хүчнүүд дээр, мөн тэмдгүүд хийгээд хуурмаг гайхалтай зүйлсээр ажилласнаар урвалт ирэхийн дарааг хүртэл ирэлт нь эс тохиох Их Эзэн, бүр Есүс буюу,

ИСО, 1 Тимот 2:4 (1 Тимот 2:4-тэй харьцуул)

(Христ бол Төрсөн Ганц Хүү бөгөөд Зууч мөн.)

4 Бүх хүмүүс аврагдахыг, мөн Бурханаас Төрсөн Ганц Хүү, мөн Бурхан

хийгээд хүмүүний хооронд Зууч байхаар томилогдсон, бүх хүмүүний дээр хүчтэй байдаг нэг Бурхан мөн Есүс Христэд үнэний мэдлэгт ирэхийг хүсдэг тэрээр буюу.

ИСО, 1 Тимот 6:15–16 (1 Тимот 6:15–16-тай харьцуул)

(Үхэшгүй байдлын гэрэл өөрсдөд нь оршдог тэд Есүсийг харж чадна.)

15 Алдар хүндтэй хийгээд сүр хүч нь үүрдийн байхаар адислагдсан цорын ганц Хаадын Хаан, мөн Эздийн Их Эзэн Потентейт тэрээр өөрийнхөө цаг үед үүнийг үзүүлэх болно;

16 Хүмүүн түүнийг хараагүй, харж ч чадахгүй, хүмүүн түүнд ойртож чадахгүй, зөвхөн гэрэлтэй бөгөөд үхэшгүй байдлын гэрэл хийгээд найдвар түүнд оршигч тэрээр буюу.

ИСО, Еврей 1:6–7 (Еврей 1:6–7-той харьцуул)

(Тэнгэр элчүүд бол тохинуулагч сүнснүүд мөн.)

6 Мөн дахин тэрээр анх төрснийгөө дэлхийд авчрах үед, мөн Бурханы бүх тэнгэр элчүүд өөрийн тохинуулагчдыг галын дөл мэт болгодог түүнийг шүтэн бишрэг.

7 Мөн тэнгэр элчүүдийн талаар тэрээр хэлэхдээ, Тэнгэр элчүүд бол тохинуулагч сүнснүүд мөн гэдэг.

ИСО, Еврей 4:3 (Еврей 4:3-тай харьцуул)

(Бурханы ажлууд дэлхийн сууринаас бэлтгэгдэв.)

3 Учир нь хэрэв тэд зүрх сэтгэлээ хатууруулах аваас тэд миний амралтад орох нь үгүй гэдгийг би хилэгнэлдээ андгайлсан хэмээн тэрээр хэлсэнчлэн, итгэсэн бид амралтад орох болно; тэрчлэн хэдийгээр Бурханы ажлууд дэлхийн сууринаас бэлтгэгдсэн байсан ч (төгсгөл болсон ч), хэрэв тэд зүрх сэтгэлээ хатууруулахгүй аваас тэд

миний амралтад ирэх болно хэмээн би андгайлсан билээ.

ИСО, Еврей 5:7–8

(ИСО-ын гар бичмэл дэх нэг тэмдэглэл шүлэг 7 болон 8 нь Христийн тухай биш, харин Мелкизедекийн талаар дурдсаныг нотлодог. Өөрөөр хэлбэл, Хаан Жеймсийн Хувилбар болон ИСО дахь сэдвүүд адил юм.)

ИСО, Еврей 6:1, 3 (Еврей 6:1, 3-тай харьцуул)

(Христийн зарчмууд төгөлдөржилт өөд хөтөлдөг.)

1 Тиймийн тул Христийн номлолын зарчмуудыг орхилгүй наманчлалын суурийг үхмэл ажлуудаас доош тавилгүй, мөн Бурханд итгэх итгэлээр төгөлдөржилт өөд явцгаая.

3 Мөн хэрэв Бурхан болгоох аваас бид төгөлдөржилт өөд явах болно.

ИСО, Еврей 7:3 (Еврей 7:3-тай харьцуул)

(Бурханы Хүүгийн жаягаарх ариун санваар эцэсгүй эсвээс эхгүй бөгөөд мөн өдрүүдийн эхлэл ч үгүй, төгсгөл ч үгүй бөлгөө.)

3 Учир нь энэхүү Мелкизедек эцэггүй, эхгүй, үр удамгүй мөн өдрүүдийн эхлэлгүй, бас амьдралын төгсгөлгүй жаяг байсан Бурханы Хүүгийн жаягийн дагуу санваартнаар томилогдсон байв. Мөн энэ санваарт томилогддог бүгд үргэлжид санваартан байж, Бурханы Хүүтэй адил болгогддог буюу.

ИСО, Еврей 7:25–26 (Еврей 7:26–27-той харьцуул)

(Христийн зуучийн үүрэг тайлбарлагдав.)

25 Учир нь ариун, гэм зэмгүй, бузарлагдаагүй, нүгэлтнүүдээс тусгаар байдаг мөн тэнгэрийн дээр захирагч болгогдсон ийм дээд санваартан бид болов.

26 Мөн өөрсдийн нүглийн учир эхлэлд мөн дараа нь хүмүүний нүглийн учир өдөр тутам золиослол өргөдөг тэдгээр дээд санваартнууд

лугаа адил бус; учир нь өөрийн нүглийн учир золиослол өргөх нь түүнд хэрэггүй билээ, учир нь нүглийг тэрээр мэддэггүй байв; харин хүмүүсийн нүглийн тулд болой. Мөн тэрээр өөрийгөө өргөснөөр үүнийг нэгэнтээ хийсэн билээ.

ИСО, Еврей 11:1 (Еврей 11:1-тэй харьцуул)

(Итгэл бол найддаг зүйлүүдээ баттай итгэх явдал мөн.)

1 Эдүгээ итгэл бол найддаг зүйлүүдээ баттай итгэн, үзээгүй зүйлүүдийг гэрчлэх явдал мөн.

ИСО, Еврей 11:35 (Еврей 11:35-тай харьцуул)

(Христийн төлөө тамлагддаг итгэлтнүүд эхний амилуулалтыг олж авна.)

35 Эмэгтэйчүүд өөрсдийн нас барагсдыг амьдралд дахин боссоноор хүлээн авчээ; мөн бусад нь эхний амилуулалтыг хүлээн авч болохын тулд чөлөөлөлтийг хүлээн авалгүй таслагдав.

ИСО, Иаков 1:2 (Иаков 1:2-той харьцуул)

(Уруу таталт биш, гай зовлон биднийг ариусахад тусалдаг.)

2 Ах дүүс минь, та нар олон гай зовлонд унасан үедээ ч үүнийг бүгдийг нь баяр хөөрт тооц.

ИСО, Иаков, 2:1 (Иаков 2:1-тэй харьцуул)

(Гишүүд нэг хүнийг нөгөөгөөс нь хэт илүү ихэд үзэх ёсгүй.)

1 Ах дүүс минь, та нар хүмүүсийг хүндлэхгүй бол, бидний Их Эзэн Есүс Христ, алдар суугийн Их Эзэнд итгэх итгэл та нарт байж чадахгүй.

ИСО, 1 Петр 3:20 (1 Петр 3:20-той харьцуул)

(Шорон дахь сүнснүүдийн зарим нь Ноагийн үед зөв шударга бус байжээ.)

20 Ноагийн өдрүүдэд тэдний зарим нь дуулгаваргүй байхад, Бурханы тэвчээр хүлээсээр байхад, хөвөгч

авдар бэлтгэгдэж байхад, эдгээр найман бодгаль буюу цөөн хэд нь үүн дотор усаар аврагдав.

ИСО, 1 Петр 4:6 (1 Петр 4:6-тай харьцуул)

(Сайн мэдээ нас барсан тэдэнд номлогддог.)

6 Үүний улмаас тэд маханбодид хүмүүний дагуу, харин Бурханы тааллын дагуу сүнсэнд амьдардаг тэд шүүгдэж болохын тулд сайн мэдээ нас барсан тэдэнд номлогддог буюу.

ИСО, 1 Петр 4:8 (1 Петр 4:8-тай харьцуул)

(Энэрэл биднийг нүгэл үйлдэхээс зайлуулдаг.)

8 Мөн бүх зүйлээс дээгүүр хүчтэй энэрэл өөрсдийн чинь дунд байдаг. Учир нь энэрэл олон нүглээс сэргийлдэг.

ИСО, 1 Иохан 2:1

(Хэрэв бид наманчлах аваас Эцэгийн өмнө Христ бидний өмгөөлөгч байх болно.)

1 Бяцхан хүүхдүүд минь, та нарыг нүгэл бүү үйлдээсэй хэмээн би эдгээр зүйлүүдийг та нарт бичиж байна. Харин, хэрэв аль ч хүмүүн нүгэл үйлдээд мөн наманчлах аваас зөв шударга бидэнд Эцэгийн өмнө Есүс Христ өмгөөлөгч байх болно.

ИСО, 1 Иохан 3:9 (1 Иохан 3:9-тэй харьцуул)

(Бурханаас төрдөг хэн ч болов, нүгэлд үргэлжлүүлдэггүй.)

9 Бурханаас төрдөг хэн боловч нүгэлд үргэлжлүүлдэггүй; учир нь Бурханы Сүнс түүнд үлддэг; мөн тэрээр нүгэлд үргэлжлүүлж чаддаггүй; учир юун гэвэл тэрээр амлалтын тэрхүү ариун Сүнснийг хүлээн авч Бурханаас төрсөн байдаг.

ИСО, 1 Иохан 4:12 (1 Иохан 4:12)

(Зөвхөн Бурханд итгэдэг хүмүүс түүнийг харж чадна.)

12 Итгэдэг тэднээс бусад хүмүүс Бурханыг ямар ч үед харсан нь үгүй. Хэрэв бид бие биенээ хайрлах аваас, Бурхан бидний дотор оршдог, мөн түүний хайр бидний дотор төгөлдөрждөг.

ИСО, Илчлэлт 1:1–4 (Илчлэлт 1:1–4-тэй харьцуул)

(Иохан Есүс Христээс илчлэлт хүлээн авч мөн үүнийг Ази дахь долоон сүмийн удирдагчдад хүргэжээ.)

1 Удахгүй тохиох ёстой зүйлүүдийг өөрийн үйлчлэгчдэд үзүүлэхийн тулд өөрийн үйлчлэгч Иоханд өөрийн тэнгэр элчийг тэрээр илгээж мөн үзүүлсэн, Бурханы үйлчлэгч Иоханы илчлэлт нь Есүс Христээс түүнд өгөгдсөн бөлгөө,

2 Бурханы Үгийг мөн Есүс Христийн тухай гэрчлэлийг, мөн үзсэн бүх зүйлээ гэрчилсэн тэрээр болой.

3 Энэхүү бошиглолын үгсийг уншдаг мөн сонсож мөн ойлгодог, мөн тэнд бичигдсэн зүйлүүдийг сахьдаг тэд адислагдсан болой, учир нь Их Эзэний ирэлтийн цаг ойрхон байна.

4 Эдүгээ энэ нь Ази дахь долоон сүмийн дээрх долоон үйлчлэгчид өгсөн Иоханы гэрчлэл болой. Байгаа мөн байсан, мөн ирэх түүний ач ивээл мөн амар амгалан та нарт байг; долоон сүмийн дээрх долоон үйлчлэгч болох тэдэнд гэрчлэхийн тулд хаан сэнтийнийхээ өмнөөс тэнгэр элчээ урагш илгээсэн түүний буюу.

ИСО, Илчлэлт 2:22 (Илчлэлт 2:22-той харьцуул)

(Ёс бусчууд тамд хаягдах болно.)

22 Болгоогтун, түүнийг, мөн тэд өөрсдийн үйлүүдийг наманчлахаас бусдаар, агуу гай зовлонд түүнтэй садар самууныг үйлддэг тэднийг би тамд хаях болно.

ИСО, Илчлэлт 5:6 (Илчлэлт 5:6)

(Бурханы Арванхоёр үйлчлэгч бүх дэлхийд илгээгдэв.)

6 Мөн хаан сэнтийний, түүнчлэн дөрвөн амьтны дунд, мөн ахлагч нарын дунд, бүх дэлхийд урагш илгээгдсэн Бурханы арванхоёр үйлчлэгч болох арванхоёр эвэртэй мөн арванхоёр нүдтэй мөнөөх алагдсан Хурга зогсож байсныг бибээр болгоож, мөн харав:

ИСО, Илчлэлт 12:1–17 (Илчлэлт 12:1–17, Сургаал ба Гэрээ 77-той харьцуул)

(Эмэгтэй хүн [Сүм], хүүхэд [Бурханы хаант улс] төмөр барцуул [Бурханы үг] луу [Сатан] болон Михаил тайлбарлагддаг. Тэнгэрт болсон дайн дэлхий дээр үргэлжилж байна.)

1 Мөн дэлхий дээрх зүйлсийн адил байдалд тэнгэрт агуу тэмдэг үзэгдэв; нараар, мөн хөл дороо сараар мөн тэргүүн дээрээ арванхоёр од бүхий титмээр хувцасласан эмэгтэй хүн үзэгдэв.

2 Мөн эмэгтэй хүүхэдтэй болж, уйлан, төрөлтөндөө зовон шаналж, мөн нярайлахын тулд ихэд өвдөв.

3 Мөн эмэгтэй бүх үндэстнүүдийг төмөр бариулаар захирах учиртай эрэгтэй хүүхэд урагш авчрав; мөн түүний хүүхэд Бурхан хийгээд түүний хаан сэнтийд дээш аваачигдав.

4 Мөн тэнгэрт өөр нэг тэмдэг үзэгдэв; мөн болгоогтун, долоон толгой мөн арван эвэртэй мөн толгойнууд дээрээ долоон титэмтэй нэгэн агуу улаан луу бөлгөө. Мөн түүний сүүл тэнгэрийн однуудын гуравны нэгийг дагуулан, тэднийг дэлхий уруу хаясан бөлгөө. Мөн сайхь Луу нярайлсан эмэгтэйн өмнө зогсон, түүний хүүхдийг төрснийх нь дараа залгихад бэлэн байв.

5 Мөн эмэгтэй аглаг буйд уруу зугтаан Бурханаас түүнд зориулан бэлтгэсэн газарт очив, ийнхүү тэд түүнийг тэнд нэг мянга хоёр зуун гурван жил тэжээх учиртай байв.

6 Мөн тэнгэрт дайн болов, Михаил болон түүний тэнгэр элчүүд лууны эсрэг тулалдав, мөн мөнөөх луу хийгээд түүний элчүүд Михаилын эсрэг тулалдав.

7 Мөн сайхь луу Михаилын ч эсрэг, мөн хүүхдийн ч, мөн өвдөлтөөсөө чөлөөлөгдөн бидний Бурхан хийгээд түүний Христийн хаант улсыг урагш авчирсан Бурханы сүм болох мөнөөх эмэгтэйг ч ноёрхсонгүй.

8 Мөн хаягдсан мөнөөх агуу луунд тэнгэрт байр олдсонгүй; тэрхүү хөгшин хорт могой чөтгөр хэмээн нэрлэгддэг байв; мөн тэрчлэн бүх дэлхийг хууран мэхэлдэг Сатан хэмээн нэрлэгддэг байв; тэрээр дэлхийд хаягдсан байв; түүний элчүүд түүнтэй хамт доош хаягдав.

9 Мөн эдүгээ аврал мөн хүч чадал мөн бидний Бурханы хаант улс, мөн түүний Христийн хүч ирэх болно хэмээн тэнгэрт хэлэх чанга дуу хоолойг би сонсов;

10 Учир нь бидний ах нарыг бидний Бурханы өмнө өдөр хийгээд шөнө буруутгасан буруутгагч доош хаягдсан буюу.

11 Учир нь Хурганы цусаар, мөн гэрчлэлүүдийнхээ үгээр тэд түүнийг дийлсэн билээ; учир нь тэд хувийнхаа амьдралыг хайрладаггүй байв, харин бүр үхэлд хүртэл гэрчлэлийг хадгалдаг байлаа. Тийм учраас, Ай тэнгэр, мөн тэнд амьдардаг та нар баяс.

12 Мөн эдгээр зүйлүүдийн дараа, Дэлхийн оршин суугчдад, тиймээ, далайн арлууд дээр оршин суудаг тэдэнд халаг хэмээн хэлэх өөр нэг дуу хоолойг би сонсов, учир нь өөрт нь цаг бага байгааг мэдсэний улмаас чөтгөр агуу хилэгнэлтэйгээр та нар дээр доош бууж ирэх гэж байна.

13 Учир нь луу өөрийгөө дэлхий уруу доош хаягдсаныг хараад, эрэг-

тэй хүүхдийг урагш авчирсан мөнөөх эмэгтэйг мөшгин хавчив.

14 Тиймийн тул, тэрээр хэсэг хугацаанд мөн цаг хугацаануудад мөн цагийн хагаст, тэнд тэжээгдэн мөнөөх хорт могойн нүүрнээс өөрийн байр, аглаг буйд уруу зугтааж болохын тулд сайхь эмэгтэйд агуу бүргэдийн хоёр далавч өгөгдсөн байлаа.

15 Мөн хорт могой тэрээр түүнийг үерт урсган хол аваачихад хүргэж болохын тулд эмэгтэйн араас амнаасаа усыг үерлүүлэн урсгав.

16 Мөн газар дэлхий эмэгтэйд тусалж, мөн газар дэлхий амаа нээн, мөн лууны амнаасаа асгасан үерийг залгив.

17 Тиймийн тул, луу эмэгтэйд уурлан хилэгнэж, мөн Бурханы зарлигуудыг сахьдаг, мөн Есүс Христийн тухай гэрчлэлтэй түүний үр удмын үлдэгдэлтэй дайн хийхээр явав.

ИСО, Илчлэл 19:15, 21 (Илчлэлт 9:15, 21-тэй харьцуул)

(Үндэстнүүдийг арчихын тулд Бурхан Христийн үгийг ашигладаг.)

15 Мөн түүний амнаас Бурханы үг гардаг, мөн үүгээр тэрбээр үндэстнүүдийг арчих болно; мөн тэрээр тэднийг амныхаа үгээр захирах болно; мөн тэрээр Бүхнийг Чадагч Бурханы догшин хилэн хийгээд хилэгнэлд дарс шахагчийг няц гишгэх болно.

21 Мөн үлдэгсэд нь морь унасан түүний үгээр алагдсан байлаа, уг үг түүний амнаас гарсан байлаа; мөн бүх жигүүртнүүд тэдний махаар дүүрсэн байв.

СҮМИЙН ТҮҮХИЙН
ОН ДАРААЛАЛ,
ГАЗРЫН ЗУРГУУД
ХИЙГЭЭД
ГЭРЭЛ ЗУРГУУД

1805 оны арванхоёрдугаар сарын 23

Иосеф Смит нь (1805–44), Ахмад Иосеф Смит, Люси Мак Смит нарын хүү болон Вермонтын Шаронд төржээ (ИС—Т 1:3-ыг үз).

1820 оны хаврын эхэн үе

Нью-Йоркийн дагуул хот Манчестер, Палмирад гэрийнхээ ойролцоох ойн цоорхойд Бошиглогч Иосеф Смит Анхны Үзэгдлээ хүлээн авчээ (ИС—Т 1:15–17).

1823 оны есдүгээр сарын 21–22

Тэнгэр элч Моронай Иосеф Смит дээр хүрч ирж Мормоны Номны цэдгийн тухай өгүүлэв. Зэргэлдээх Кумора гүвээнд булсан алтан ялтсуудыг Иосеф үзжээ (ИС—Т 1:27–54).

1827 оны есдүгээр сарын 22

Кумора гүвээн дээр Иосеф Смит Моронайгаас алтан ялтсуудыг хүлээн авав (ИС—Т 1:59).

1829 оны тавдугаар сарын 15

Пеннсилванийн Хармонид Иосеф Смит Оливер Каудери хоёрт Иохан Баптист Аароны санваар хүртээжээ (С ба Г 13; ИС—Т 1:71–72-ыг үз).

1829 оны тавдугаар сар

Пеннсилванийн Хармони болон Нью-Йоркийн Колесвилл хоёрын хоорондох Сасквиханна голын ойролцоо Иосеф Смит Оливер Каудери хоёр Мелкизедек санваарыг Петр, Иаков, Иохан нараас хүлээн авав (С ба Г 128:20-ийг үз).

1829 оны зургадугаар сар

Мормоны Номны орчуулга дуусав. Гурван гэрч болон Найман гэрч алтан ялтсуудыг үзжээ (2 Ниф. 11:3; 27:12–13; С ба Г 17-г үз).

1830 оны гуравдугаар сарын 26

Нью-Йоркийн Палмирад анхны хэвлэмэл Мормоны Ном ашиглагдах болов.

1830 оны дөрөвдүгээр сарын 6

Нью-Йоркийн Фейетте хотхонд Сүм зохион байгуулагдав.

1830 оны ес—аравдугаар сар

Леменчүүдэд (Америкийн уугуул оршин суугчид) номлох анхны номлогчид дуудагджээ (С ба Г 28; 30; 32).

1830 оны арванхоёрдугаар сараас—1831 оны нэгдүгээр сар

Гэгээнтнүүд Огайод цуглахаар зарлигдуулав (С ба Г 37; 38:31–32).

1831 оны долдугаар сарын 20

Сионы хот (Шинэ Иерусалим) баригдах газар Миссурийн Индепенденст буй нь Бошиглогч Иосеф Смитэд илчлэгджээ (С ба Г 57; ИТ 1:10).

1833 оны гуравдугаар сарын 18

Сидней Ригдон Фредерик Г.Виллямс хоёр Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөлд зөвлөхүүд байхаар томилогдож (С ба Г 81-ийн толгой гарчгийг үз) мөн энэхүү сүүлчийн хаант улсын түлхүүрүүд өгөгджээ (С ба Г 90 гарчиг; шүлэг 6-г үз).

1833 оны арваннэгдүгээр сарын 7

Миссурийн Жаксон гүнлэг дэх танхайрагч бүлгүүдээс зугтан, Гэгээнтнүүд Миссури мөрнийг гатлан, Миссурийн Клей гүнлэг уруу дүрвэж эхлэв.

1834 оны тавдугаар сарын 5

Жаксон гүнлэгээс албадуулан нүүсэн Гэгээнтнүүдэд итгэл төрүүлэхийн тулд Сионы

хуарангийн удирдагчийн хувьд Ерөнхийлөгч Иосеф Смит Огайогийн Көртландыг орхин Миссури уруу явжээ.

1835 оны хоёрдугаар сарын 14

Огайогийн Көртландад Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга зохион байгуулагдав (С ба Г 107:23–24).

1835 оны хоёрдугаар сарын 28

Огайогийн Көртландад Нэгдүгээр Далын Чуулгын зохион байгуулалт эхэлжээ.

1835 оны наймдугаар сарын 17

Огайогийн Көртландад Сургаал ба Гэрээ Сүмийн жишиг бүтээлээр зөвшөөрөгдөв.

1836 оны гуравдугаар сарын 27

Көртландын Ариун Сүм онцгойлон адислагдав (С ба Г 109).

1836 оны дөрөвдүгээр сарын 3

Көртландын Ариун сүмд Иосеф Смит Оливер Каудери хоёр дээр Есүс Христ хүрч иржээ. Мосе, Елиас болон Елиа хүрч ирж, санваарын түлхүүрүүдийг итгэл хүлээлгэн өгөв (С ба Г 110).

1837 оны долдугаар сарын 19

Хебер С.Кимбалл болон бусад зургаан хүн Сүмийн далайн чанд дахь номлолоор Английн Ливерпүүлд хүрч ирэв.

1838 оны дөрөвдүгээр сарын 26

Сүмийн нэр илчлэлтээр тодорхой болов (С ба Г 115:4-г үз).

1838 оны арванхоёрдугаар сарын 1

Миссурийн Клей гүнлэгийн Либерти дэх Либертийн Шоронд Бошиглогч

<p>Иосеф Смит болон бусад хүмүүс хоригдов (С ба Г 121–123-ыг үз).</p> <p>1840 оны наймдугаар сарын 15 Нас барагсдын төлөөх багтисмыг Бошиглогч Иосеф Смит нийтэд зарлав.</p> <p>1841 оны аравдугаар сарын 24 Абрахамын хүүхдүүд эргэж ирэхийн төлөө Ахлагч Оорсон Хайд Ариун нутгийг онцгойлон адислав (С ба Г 68:1–3; 124:128–129).</p> <p>1842 оны гуравдугаар сарын 17 Иллинойн Наувуд эмэгтэйчүүдийн Халамжийн Нийгэмлэг зохион байгуулагджээ.</p> <p>1842 оны тавдугаар сарын 4 Анхны ариун сүмийн бүрэн хишиг хүртээлт өгөгдөв.</p> <p>1844 оны зургадугаар сарын 27 Картейж шоронд Иосеф Смит Хайрум Смит хоёр алагджээ (С ба Г 135-ыг үз)</p> <p>1846 оны хоёрдугаар сарын 4 Наувугийн Гэгээнтнүүд өрнөд тийш нүүхээр Миссисипи мөрнийг гаталж эхлэв. Дорнодын зарим Гэгээнтнүүд Нью-Йорк хотоос Калифорни уруу Брүүклин усан онгоцоор явжээ.</p> <p>1846 оны долдугаар сарын 16 Мормоны суман Нэгдсэн Улсад алба хаахаар Айовад цугларав.</p> <p>1847 оны дөрөвдүгээр сар Ерөнхийлөгч Бригам Янгийн анхдагчуудын хамтлаг Винтер Квортерсыг орхин өрнөд тийш аялалд гарав (С ба Г 136).</p>	<p>1847 оны долдугаар сарын 24 Ерөнхийлөгч Бригам Янг Солт Лейкийн Хөндийд орж ирэв.</p> <p>1847 оны арванхоёрдугаар сарын 27 Сүмийн чуулган Ерөнхийлөгч Бригам Янг, Ахлагч Хибер С.Кимбалл, Ахлагч Виллард Ричардс нарыг Тэргүүн Зөвлөлөөр баталсан байна.</p> <p>1848 оны тав—зургадугаар сар Солт Лейкийн Хөндийд хүүрэлзгэнэ ургацыг сүйтгэв. Цахлайн сүрэг хүүрэлзгэнүүдийг идсэнээр талбай бүрэн сүйтгэгдэхээс аврагдсан ажээ.</p> <p>1849 оны арванхоёрдугаар сарын 9 Ричард Валантин Ням гарагийн Сургуулийг зохион байгуулжээ.</p> <p>1850 оны зургадугаар сарын 15 Солт Лейк Хотод <i>Deseret News</i> хэвлэгдэж эхлэв.</p> <p>1856 оны аравдугаар сар Вилли болон Мартины гар тэрэгний хамтлагууд эхний цасан шуургануудад саатжээ. Тэднийг Солт Лейкийн Хөндийн аврах баг олжээ.</p> <p>1867 оны арванхоёрдугаар сарын 8 Ерөнхийлөгч Бригам Янгийн удирдлаган дор Халамжийн Нийгэмлэг дахин зохион байгуулагджээ.</p> <p>1869 оны арваннэгдүгээр сарын 28 Залуу Эмэгтэйчүүдийн хөтөлбөрийн өмнө оршиж байсан Залуу Эмэгтэйчүүдийн Хэмнэлтийн нийгэмлэг зохион байгуулагдав.</p> <p>1875 оны зургадугаар сарын 10 Залуу Эрэгтэйчүүдийн хөтөлбөрийн өмнө оршиж</p>	<p>байсан Залуу Эрэгтэйчүүдийн Харилцан сайжралтын нийгэмлэг зохион байгуулагдав.</p> <p>1877 оны дөрөвдүгээр сарын 6 Сейнт Жоржийн Ариун сүм онцгойлон адислагдав. Санваарын байгууллага болон Сионы гадаснуудыг эмх журамд оруулах тухай илчлэлтийг Ерөнхийлөгч Бригам Янг хүлээн авчээ.</p> <p>1878 оны наймдугаар сарын 25 Ютагийн Фармингтонд Аурелиа Спенсер Рожерс Хүүхдийн Хэсгийн анхны цуглааныг явуулжээ.</p> <p>1880 оны аравдугаар сарын 10 Жон Тейлор Сүмийн Ерөнхийлөгчөөр батлагдав. Агуу Үнэт Сувд жишиг бүтээлээр хүлээн зөвшөөрөгдөв.</p> <p>1883 оны дөрөвдүгээр сарын 14 Далуудыг зохион байгуулах тухай Жон Тейлорт илчлэлт өгөгдөв.</p> <p>1889 оны дөрөвдүгээр сарын 7 Вилфорд Вудрафф Сүмийн Ерөнхийлөгчөөр батлагдав.</p> <p>1890 оны аравдугаар сарын 6 Ерөнхий чуулганаар “Тунхаглал” батлагдаж, олон эхнэртэй байх ёсыг зогсоохыг мэдэгдэв (АТ—1-ийг үз).</p> <p>1893 оны дөрөвдүгээр сарын 6 Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф 40 жил барьсан Солт Лейкийн Ариун сүмийг онцгойлон адислав.</p> <p>1898 оны есдүгээр сарын 13 Лорензо Сноү Сүмийн Ерөнхийлөгч болов.</p>
---	---	---

<p>1899 оны тавдугаар сарын 17 Аравны нэгд онцгой анхаарахыг түүнд шавдуулсан илчлэлтийг Сейнт Жоржид Ерөнхийлөгч Лорензо Сноү хүлээн авчээ (С ба Г 119-ийг үз).</p>	<p>1964 оны аравдугаар сар Гэр бүлийн үдшийг сахин баримтлахыг дахин онцолж үзэв.</p>	<p>албан ёсоор Далаас дуудаж эхлэв.</p>
<p>1901 оны аравдугаар сарын 17 Иосеф Ф.Смит Сүмийн Ерөнхийлөгч болов.</p>	<p>1970 оны нэгдүгээр сарын 23 Иосеф Фийлдинг Смит Сүмийн Ерөнхийлөгч болов.</p>	<p>1985 оны арваннэгдүгээр сарын 10 Эзра Табт Бенсон Сүмийн Ерөнхийлөгч болов.</p>
<p>1918 оны аравдугаар сарын 3 Ерөнхийлөгч Иосеф Ф.Смит нас барагсдыг аврах тухай үзэгдэл хүлээн авчээ (С ба Г 138-ыг үз).</p>	<p>1971 оны нэгдүгээр сар Сүмийн шинэ сэтгүүлүүд—<i>Ensign, New Era</i>, болон <i>Friend</i> нийтлэгдэж эхлэв.</p>	<p>1989 оны дөрөвдүгээр сарын 1 Далын Хоёрдугаар Чуулга дахин зохион байгуулагдав.</p>
<p>1918 оны арваннэгдүгээр сарын 23 Хибер Ж.Грант Сүмийн Ерөнхийлөгч болов.</p>	<p>1972 оны долдугаар сарын 7 Харолд Б.Ли Сүмийн Ерөнхийлөгч болов.</p>	<p>1994 оны зургадугаар сарын 5 Ховард В.Хантер Сүмийн Ерөнхийлөгч болов.</p>
<p>1936 оны дөрөвдүгээр сар Эдийн Засгийн Их Уналтын үед ядууст туслахын тулд Сүмийн Аюулгүй Байдлын Хөтөлбөр үндэслэгдэн бий болж, Сүмийн халамжийн хөтөлбөр болов. Энэ хөтөлбөр Ерөнхийлөгч Хибер Ж.Грантын өмнө нь хүлээн авсан илчлэлтээс гараагаа эхлэн хөгжжээ.</p>	<p>1973 оны арванхоёрдугаар сарын 30 Спенсер В.Кимбалл Сүмийн Ерөнхийлөгч болов.</p>	<p>1995 оны гуравдугаар сарын 12 Гордон В.Хинкли Сүмийн Ерөнхийлөгч болов.</p>
<p>1941 оны дөрөвдүгээр сарын 6 Арванхоёрын туслахууд анх удаа дуудагдав.</p>	<p>1975 оны аравдугаар сарын 3 Далын Нэгдүгээр Чуулгыг дахин байгуулсныг Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл мэдэгдэв.</p>	<p>1995 оны дөрөвдүгээр сарын 1 Бүсийн төлөөлөгчийн албан тушаал цуцлагдав. Удирдлагын шинэ албан тушаалыг Бүсийн Эрх Мэдэлтэн хэмээн зарлав.</p>
<p>1945 оны тавдугаар сарын 21 Жорж Алберт Смит Сүмийн Ерөнхийлөгч болов.</p>	<p>1976 оны дөрөвдүгээр сарын 3 Агуу Үнэт Сувдад хоёр илчлэлт нэмэгдэв. 1981 онд тэдгээрийг С ба Г хэсэг 137, 138 болгон шилжүүлжээ.</p>	<p>1995 оны есдүгээр сарын 23 Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн зөвлөлөөс “Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг” — ийг хэвлүүлэв.</p>
<p>1951 оны дөрөвдүгээр сарын 9 Давид О.МкКей Сүмийн Ерөнхийлөгчөөр батлагдав.</p>	<p>1978 оны есдүгээр сарын 30 Үндэс угсаа буюу арьсны өнгө харгалзахгүйгээр санваарыг зохистой бүх эрэгтэй гишүүдэд хүртээх тухай илчлэлт Сүмээр дэмжин батлагдав (АТ—2-ыг үз).</p>	<p>1997 оны есдүгээр сарын 5 Бүсийн Эрх Мэдэлтнүүд Далуудаар томилогдох болов. Далын Гуравдугаар, Дөрөвдүгээр, Тавдугаар Чуулгууд зарлагдав.</p>
<p>1961 оны есдүгээр сарын 30 Гэр бүл болон хувь хүнийг бэхжүүлэхийн тулд Сүмийн бүх хөтөлбөр санваараар дамжин зохицуулагдах ёстой хэмээн Ахлагч Харолд Б.Ли Тэргүүн Зөвлөлийн удирдлаган дор мэдэгджээ.</p>	<p>1979 оны наймдугаар сар Хаан Жеймсийн Библийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хэвлэл, судлах тусламжийн хамт хэвлэгдэв.</p>	<p>1997 оны аравдугаар сарын 4 Ерөнхийлөгч Хинкли жижиг ариун сүмүүд барихаар зарлав.</p>
	<p>1981 оны есдүгээр сар Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувдын шинэ хэвлэл англи хэлээр хэвлэгдэв.</p>	<p>1997 оны арваннэгдүгээр сар Сүмийн гишүүнчлэл 10 саяд хүрэв.</p>
	<p>1984 оны зургадугаар сар Бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлүүдэд гишүүдийг</p>	<p>1998 оны дөрөвдүгээр сар 2000 он гэхэд үйлчлэлд буй 100 ариун сүмтэй болох зорилгыг Ерөнхийлөгч Хинкли зарлав.</p>

Сүмийн түүхэнд холбогдох газруудын эдгээр чухал гэрэл зургууд нь Хожмын Үеийн анхны Гэгээнтнүүдийн алхалж явсан, орчин үеийн бошиглогчдын амьдарч мөн заан сургаж байсан, мөн судрын олон үйл явдлууд болсон газар нутгуудын дүрслэл юм. Судлах явцдаа гэрэл зургуудыг илүү сайн ашиглахад тань туслахын тулд гэрэл зураг бүрд бага хэмжээний тайлбаруудыг хавсаргасан болно. Тайлбар болон гарчгийн дугаар нь нэг ижил дугаар болон

гарчигтай гэрэл зурагтай холбоотой. Тайлбарын нэрний дараах эхний догол мөр нь гэрэл зургийн байдлыг, түүний дотор харвал зохих чухал зүйлүүд хийгээд гэрэл зураг хаашаа харсныг олонтаа тайлбарласан байдаг. Дараа нь судрын чухал үйл явдлуудын талаар илүү их зүйлийг та нар хаанаас уншиж болохыг мэдэхийн тулд тухайн нутагт болсон үйл явдлуудыг судрын ишлэлүүдийн хамт жагсаасан болно.

1. Ойн ариун цоорхой

Ойн ариун цоорхой нь Нью-Йоркийн дагуул хот Манчестерын Палмирад байдаг. Ойн цоорхой 1820 онд Смитийн гэр бүлийн жижигхэн дүнзэн байшин байсан газрын яг зүүн талд байдаг.

Онцгой үйл явдал: Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёр ойн энэ цоорхойд Бошиглогч Иосеф Смит дээр хүрч ирсэн билээ (ИС—Т 1:14–20).

2. Кумора гүвээ ба Манчестр Палмирагийн бүс нутаг

Умард уруу харсан энэ гэрэл зураг Нью-Йоркийн Манчестр дахь Кумора гүвээг харуулжээ. Кумора гүвээ гэрэл зургийн баруун гар талын доод булангаас эхлэн гэрэл зургийн дээд хэсгийн талаас ялигүй өнгөртөл үргэлжилж байна. Гүвээний хойт талын төгсгөлд харагдаж байгаа цагаан хөшөөг тэнгэр элч Моронай болон Мормоны Номны ирэлтийг хүндэтгэн босгожээ. Кумора гүвээ нь Ойн ариун цоорхойгоос зүүн урагш 5 км-т байрладаг. Гэрэл зургийн дээд хэсгийн ойролцоо зургаа аравны таван километр хол зайд Палмира байдаг. Смитийн ферм, Ойн ариун цоорхой хоёр гэрэл зургийн зүүн дээд талд оршдог.

Онцгой үйл явдлууд: Бошиглогч Иосеф Смитийн гэр бүл Анхны Үзэгдлийн үед энэ газар амьдарч байв (ИС—Т 1:3). мэ 421 онд Моронай өөрийн хүмүүсийн нандин түүхийг агуулсан багц алтан ялтсуудыг Кумора гүвээнд булжээ (Морм. үгс 1:1–11; Морм. 6:6; Моро. 10:1–2). Мөн ялтсуудыг гүвээний бараг оройд, гүвээний хойд үзүүрийн баруун талаас олж болохыг Моронай Иосеф Смитэд хэлжээ. Моронай тэдгээрийг түүнд 1827 онд өгчээ (С ба Г 27:5; 128:20; ИС—Т 1:33–35, 51–54, 59).

3. Ахмад Иосеф Смитийн дүнзэн байшин

Нью-Йоркийн Палмирагийн ойролцоох анхны дүнзэн байшингийн байран дээр дууриалган барьсан Ахмад Иосеф Смитийн гэр. Смитийн гэр бүл Палмирад ирээд удалгүй анхныхаа нэг, нэг хагас давхар засмал дүнзэн байшинг барьжээ.

Онцгой үйл явдлууд: Бошиглогч Иосеф Смит аль сүм үнэн бэ гэдгийг мэдэхийн төлөө хичээж байсан үедээ энэ байшинд Библиэс суралцдаг байв (ИС—Т 1:11–13). Моронай Иосеф дээр хүрч ирсэн, Мормоны Номны ялтсуудын тухай түүнд хэлсэн ажээ (ИС—Т 1:30–47).

4. Грандины Дардсын болон Хэвлэх үйлдвэр

1830 онд Мормоны Номны анхны хувиуд хэвлэгдсэн, дахин сэргээсэн түүхийн дурсгалт Эгберт Б.Грандины байшин доторх хэвлэх цех. Мормоны Номыг 5000 хувь хэвлэх зардлыг төлөхийн тулд Мартин Харрис фермээ барьцаанд тавин, хагасыг нь заржээ. 1829 онд үсэг өрөлт эхэлж, 1830 оны гуравдугаар сарын 26-нд хэвлэмэл хувиуд бэлэн болсон байна.

Онцгой үйл явдал: Мартин Харрис Мормоны Номыг хэвлэх зардлыг төлөхийн тулд эд хөрөнгөнөөсөө үнэгүй зориулахаар зарлигдуулсан байв (С ба Г 19:26–35).

5. Сасквиеханна гол

Энэ гэрэл зураг Пеннильванийн Хармони хотхон дахь Сасквиеханна голыг харуулжээ.

Онцгой үйл явдлууд: Бага Иосеф Смит ажил олохын тулд 1825 онд анх удаа Хармонид иржээ. Тэрээр эцгийнхээ хамт ирээдүйнхээ эхнэр Эмма Хейлтэй анх танилцсан Исаак Хейлийн гэрт эндээс холгүйхэн амьдарч байжээ (ИС—Т 1:56–57). 1827 оны нэгдүгээр сарын 18-нд Иосеф Эмма хоёр гэрлэжээ.

1827 оны есдүгээр сарын 22-нд Нью-Йоркийн Манчестрт Бошиглогч алтан ялтсуудыг хүлээн авч мөн түүнээс хойш нэн удалгүй тэрээр хуудаснуудыг орчуулж эхэлсэн Хармонид, голын ойролцоох өөрсдийнхөө гэрт Эмматай хамт нүүн очжээ. Мормоны Номны орчуулгын үеэр Иосеф Оливер Каудери хоёр баптисмын талаар илүү ихийг мэдэхийг хүсч энэ асуудлын талаар Их Эзэнээс асуухаар гол уруу очсон ажээ. Уг залбирлын хариуд 1829 оны тавдугаар сарын 15-нд Иохан Баптист хүрч иржээ (ИС—Т 1:66-74; С ба Г 13). Тэрээр Аароны санваарыг Иосеф Оливер хоёрт хүртээсэн байна. Тэгээд тэд энэ гол дотор орж нүглүүдийн ангижралын төлөө бие биендээ баптисм хүртээжээ. Тэгээд Иосеф Оливер хоёр бие биенээ Аароны санваарт томилохыг Иохан Баптист зааварлажээ. Үүнээс хойш нэн удалгүй Петр, Иаков, Иохан нар энэ голын эрэг дээр хүрч ирэн, Иосеф Оливер хоёрыг Мелкизедек санваарт томилжээ (С ба Г 27:12-13; 128:20).

6. Ахмад Петр Витмерийн дүнзэн байшин

Нью-Йоркийн Фейетте дэх анхны байшингийн суурин дээр шинэчлэн барьсан Ахмад Петр Витмерийн дүнзэн байшин.

Онцгой үйл явдлууд: 1829 оны зургадугаар сарын сүүлчээр энд Иосеф Смит Мормоны Номыг орчуулж дуусчээ. Энэ байшингийн ойролцоох ойд Гурван гэрч тэнгэр элч Моронай болон алтан ялтсуудыг харсан байна. Тэдний гэрчлэл эдүгээ Мормоны Номны бүх хувь дээр хэвлэгдсэн байдаг. 1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд Петр Витмерийн гэрт ойролцоогоор 60 хүн цугларч Есүс Христийн Сүмийн хуучин үйл ажиллагааг гэрчилжээ. Сүмийн эхэн үеийн анхны цуглаанууд болон чуулганууд энд болжээ. Сургаал ба Гэрээний илчлэлтүүдийн хорь нь Петр Витмерийн гэрт хүлээн авагдсан ажээ.

7. Ньюел К.Витней болон Компанийн дэлгүүр

Энэ дэлгүүр Көртландын Сүмийн түүхэнд гол үүрэг гүйцэтгэсэн юм. Хэсэг хугацаанд Иосеф Эмма Смит хоёр энд богино хугацаанд амьдарч байв. 1832 онд энэ нь Сүмийн захиргааны төв байр болжээ. Энд хэд хэдэн онцгой илчлэлт хүлээн авагдсан билээ. 1833 оны нэгдүгээр сарын 24-нөөс 1833 оны дунд үе хүртэл энэ дэлгүүрт Бошиглогчдын Сургууль хичээллэж байв.

Онцгой үйл явдлууд: Мэргэн Ухааны Үгийн илчлэлтийг Бошиглогч Иосеф хүлээн авчээ (С ба Г 89). Тэрээр Библийг орчуулах ажлын ихэнхийг энд хийжээ.

8. Жон Жонсоны Гэр

Жон Жонсон болон Алис Жонсоны гэр нь Огайогийн Хайрамд байдаг байв. Энэ өрөө хоёрдугаар давхарт байдаг.

Онцгой үйл явдлууд: Бошиглогч Иосеф Смит түүний эхнэр Эмма хоёр энэ байшинд амьдарч байв. Иосеф Сидней Ригдон хоёр алдар суугийн зэрэглэлүүдийн тухай гайхамшигт үзэгдлийг 1832 оны хоёрдугаар сарын 16-нд өөр хэдэн хүний дэргэд хүлээн авчээ (С ба Г 76). Тэрчлэн энэ байшинд бошиглогч Иосеф Смит Библийн Иосеф Смитийн Орчуулган дээр ажиллаж байв. 1832 оны гуравдугаар сарын 24-нд Иосеф, Эмма хоёрыг энд амьдарч байхад урвагчдын танхайрагч бүлэг болон Мормончуудыг эсэргүүцэгчид Иосеф Сидней хоёрыг хүндээр зодож, давирхайдаж өд наажээ.

9. Көртландын Ариун сүм

Көртландын Ариун сүм Огайогийн Көртландад байдаг.

Онцгой үйл явдлууд: Көртландын Ариун сүм бол энэ эрин үед баригдсан анхны ариун сүм байв (С ба Г 88:119; 95). Энэ ариун сүмд Иосеф Смит селестиел хаант улсын тухай үзэгдлийг харжээ (С ба Г 137). Ариун сүм 1836 оны гуравдугаар сарын 27-нд онцгойлон адислагдсан билээ (С ба Г 109). 1836 оны дөрөвдүгээр сарын 3-нд Аврагч ирж мөн өөрийнхөө үгийг өөрийн хүмүүст илчлэх газар болох ариун сүмийг хүлээн зөвшөөрсөн юм (С ба Г 110:1-10). Энэхүү ирэлтийн дараа Иосеф Смит Оливер Каудери хоёр санваарын зарим гүлхүүрүүд болон чухал мэдээллийг өөрсдөл нь өгсөн Мосе, Елиас, мөн Елиа нарын айлчлалыг хүлээн авсан билээ (С ба Г 110:11-16). Гэгээнтнүүд хавчлагын улмаас Көртландаас дүрвэхээс өмнө энэхүү ариун сүм хоёр жил шахам тэдэнд үйлчилжээ.

10. Адам-ондай-Аманы хөндий

Зүүн тийш үргэлжилсэн Адам-ондай-Аманы хөндий нь Миссурийн баруун хойно Галлатин хотын ойролцоо байдаг анир чимээгүй, үзэсгэлэнт хөндий юм.

Онцгой үйл явдлууд: Нас барахаасаа гурван жилийн өмнө Адам өөрийнхөө зөв шударга үр удмыг энэ хөндийд дуудаж, тэдэнд сүүлчийнхээ адислалыг өгсөн ажээ. (С ба Г

107:53–56). 1838 онд Адам-ондай Аман нь 500-аас 1000 Хожмын Үеийн Гэгээнтний суурьшсан газар байв. Гэгээнтнүүд Миссуригээс хөөгдөхдөө энэ суурьшлаа орхин явжээ. Христийн Хоёр дахь Ирэлтийн өмнө Адам болон үе үеийн Гэгээнтнүүдийг оролцуулан, түүний зөв шударга үр удам Аврагчтай уулзахаар энэ хөндийд дахин цуглах болно (Дан. 7:9–10, 13–14; С ба Г 27; 107:53–57; 116:1).

11. Фар Вестийн Ариун Сүмийн газар

Миссурийн Фар Вест суурин нь мөрдлөг хавчлагаас зугтан орогнох газар хайж байсан Жаксон болон Клей гүнлэгийн 3000-аас 5000 Гэгээнтний гэр орон болсон билээ. 1838 оны аравдугаар сарын 31-нд Бошиглогч Иосеф Смит болон Сүмийн бусад удирдагчид баригдаж Ричмондод шүүх хурал хийсний дараа Либерти Шоронд хоригджээ. 1838–39 оны өвлийн үеэр Хожмын Үеийн Гэгээнтнүүд Фар Вестээс хөөгдөж, Миссурийн нөгөө талд Иллинойд дахин суурьшжээ.

Онцгой үйл явдлууд: Ариун сүмийн газар онцгойлон адислагдаж мөн тулгын чулуу нь тавигджээ. Сургаал ба Гэрээнд хэвлэгдсэн долоон илчлэлт хүлээн авагдсан байна (хэсэг 113–15; 117–20). Сүмийн зургаа дахь Ерөнхийлөгч Иосеф Ф.Смит Фар Вестэд 1838 онд төржээ. Фар Вест нь Иосеф Смитийн тэргүүлсэн Сүмийн удирдлагын төвөөр богино хугацаанд үйлчилсэн аж.

12. Либертийн Шорон

Миссурийн Либертид байдаг жижигхэн шорон. 1838 оны арванхоёрдугаар сарын 1-нээс 1839 оны дөрөвдүгээр сарын 6 хүртэл Иосеф Смит болон бусад ах нар 1.2 метр зузаан ханан дотор хоригдож байжээ. (Сидней Ригдон хоёрдугаар сарын сүүлчээр суллагдсан байна). Гяндангийн доод хэсэг буюу байшингийн газар доорх хэсэгт тэд, дэрс дэвссэн хүйтэн чулуун дээр багахан гэрэлд хүйтэн өвлөөс ялимгүй хамгаалагдан унтаж байжээ.

Онцгой үйл явдал: Бошиглогч Иосеф Смит Миссуригээс хөөгдсөн мянга мянган Гэгээнтний төлөө гуйж, цөлөгдсөн Гэгээнтнүүдэд хандсан захидалдаа бичсэн залбирлынхаа хариуг хүлээн авчээ (С ба Г 121–23).

13. Науву дахь Ордон гэр

1843 оны наймдугаар сард Бага Иосеф Смит болон түүний гэр бүл Наувугийн Ордон гэрт нүүж иржээ. Хожим нь нийт 22 өрөө-

тэй гол барилгын зүүн талд өргөтгөл нэмсэн байна. 1844 оны нэгдүгээр сарын эхээр Эбенезер Робинсон байшинг зочид буудал болгон зассан бөгөөд Бошиглогч 6 өрөөг нь гэр бүлдээ үлдээн авчээ. Энэ байшин зарим талаараа Наувугийн олон нийтийн төв байсан юм. Энд Бошиглогч дээд зиндааныхныг хүлээн авч байжээ.

Онцгой үйл явдлууд: 1844 оны зургадугаар сарын 27-нд Бошиглогч Иосеф, түүний ах Хайрум хоёр Иллинойн Картейж шоронд буудуулан алагдсан бөгөөд оршуулахаас нь өмнө тэдний цогцсыг олон нийтэд үзүүлэхийн тулд энэ байшинд авчирчээ. Тэднийг гол гудамжны эсрэг талд, Наувуд анх ирэхдээ Иосефын амьдарч байсан хуучин модон байшингийн баруунтаах, гэр бүлийн жижигхэн оршуулгын газарт оршуулжээ. Эмма Смит 1871 он хүртэл Ордон Гэрт амьдарч байв. Дараа нь тэрээр 1879 онд тэнд нас барсан Наувугийн гэртээ шилжиж иржээ.

14. Бошиглогч Иосеф Смитийн Улаан тоосгон дэлгүүр

Дахин засварласан Иосеф Смитийн дэлгүүр Иллинойн Наувуд байдаг. Энэ нь Сүм Наувуд байх үед хамгийн чухал барилгын нэг байжээ. Зөвхөн дэлгүүр төдийгүй олон нийт, эдийн засаг, улс төр болон шашны үйл ажиллагааны гол төв болж байжээ. Иосеф Смит хоёрдугаар давхрыг нь албаны өрөөнүүд болгосон ажээ.

Онцгой үйл явдлууд: Ариун сүм баригдаж дуусахаас өмнө дэлгүүрийн дээд талын өрөө нь анхны бүрэн хишиг хүртээх ёслол хийгдсэн ёслолын өрөө байв. 1842 оны гуравдугаар сарын 17-нд Бошиглогч Иосеф Сүмийн эмэгтэйчүүдийг Халамжийн нийгэмлэг болгон зохион байгуулсан байна.

15. Наувугийн Ариун сүм

Наувугийн Ариун сүмийн энэхүү багасгасан загвар анхны ариун сүмийн суурин дээр байдаг. Ариун сүм нутгийн цагаан саарал шохойн чулуугаар баригджээ. Барилга нь 39 метр урт, 27 метр өргөн юм. Орой нь газрын түвшнээс 48 метр өндөр. 1841 онд баригдаж эхэлсэн энэ үзэсгэлэнт ариун сүмийг барихын тулд Сүмийн гишүүд агуу золиослол хийжээ. Зарим нь барилга дээр хэдэн сараар ажиллаж байв; бусад нь мөнгөө өргөл болгон өгсөн юм. Хэдийгээр бүрэн баригдаагүй ч, тэднийг Өрнөд уруу зугтаж байсан саруудад ёслол хийлгүүлэхээр ирэх гишүүдээр ариун сүм дүүрч бай-

жээ. 1846 оны хаврын эхээр танхайрагчдын хүчинд автан олон гэгээнтэн Наувуг орхин явах үед, ариун сүмийг гүйцээх тусгай бүлэг хүмүүс ард хоцорсон байна. 1846 оны дөрөвдүгээр сарын 30-нд Ахлагч Оорсон Хайд, Вилфорд Вудрафф болон ойролцоогоор хориод хүн Их Эзэний энэ өргөөг онцгойлон адисалсан юм. Үлдсэн Сүмийн гишүүд есдүгээр сард Наувугаас хөөгдөх үед ариун сүм эзлэгджээ; ариун шүтээний барилгыг танхайрагчид хүч хэргэлэн бузарлаж мөн бохирложээ. 1848 оны аравдугаар сард үүнийг шатаан устгасан байна.

Онцгой үйл явдлууд: 1845 оны аравдугаар сарын 5-нд ариун сүмийн хурлын танхимд Ерөнхий чуулган явагджээ. 1845 оны арванхоёрдугаар сарын 10-нд эхэлсэн Хишиг хүртээх ажил 1846 оны хоёрдугаар сарын 7-ныг хүртэл үргэлжилсэн ажээ. 5500-гаас илүү Хожмын Үеийн Гэгээнтэн хишиг хүртээх мөн нас барагсдын төлөө олон баптисм хийгээд лацдалт гүйцэтгэгджээ.

16. Картейжийн Шорон

Иллинойн Картейж хот дахь шорон.

Онцгой үйл явдлууд: Иосеф Смит, түүний ах Хайрум хоёр 1844 оны зургадугаар сарын 24-нд Картейжид иржээ. Тэд урвагчдын худал мэдүүлгийн улмаас зургадугаар сарын 25-нд энэ шоронд оржээ. Зургадугаар сарын 27-нд нүүрээ хараар будсан ойролцоогоор 100 гаруй танхайрагчид шорон уруу дайрсан байна. Иосеф Хайрум хоёр буудуулан алагдаж, Жон Тейлор хэд хэдэн удаа шархаджээ. Гайхалтай нь Вилард Ричардс шархдаагүй байв. Хожим нь Сургаал ба Гэрээний хэсэг 135 дахь бурханлигаар нөлөөлөгдсөн дурсамжаа Жон Тейлор бичсэн ажээ.

17. Вестээс гарсан нь

Иллинойн Наувугаас дүрвэлт гурав—дөрөвдүгээр сард эхлэхээр төлөвлөгдөж байсан боловч танхайрагчдын шахалтаар 1846 оны хоёрдугаар сард эхэлсэн, Миссиссипи мөрнийг Гэгээнтнүүд гатлах үйл явцыг Ерөнхийлөгч Бригам Янг удирджээ. Ерөнхийлөгч Янг гэгээнтнүүдийн хишиг хүртээлтийг гүйцэтгэхээр ард үлдсэн бөгөөд хоёрдугаар сарын дунд үе хүртэл Наувуг орхин яваагүй юм.

Онцгой үйл явдлууд: Бошиглогч Иосеф Смит нас барахынхаа өмнө “Та нарын зарим нь хотууд барьж мөн оршин суухад тусалж, Гэгээнтнүүд Хадат Уулсын дунд агуу хүмүүс болохыг үзэх хүртлээ амьдрах болно” хэмээн бошигложээ. 1846 оны хоёрдугаар сараас есдүгээр сар хүртэл бараг 12000 Гэгээнтэн Наувугаас явжээ. Дараачийн байрлал Винтер Квортерсоос Гэгээнтнүүд явсны дараа арав, тавь, зуутын бүлгүүдэд ахмадын удирдлага дор зохион байгуулагдсан ажээ (С ба Г 136:3). 1846 оны есдүгээр сард ойролцоогоор 800 гаруй зэвсэглэсэн танхайрагчид зургаан их буугаар Наувуг тойруулан бүсэлжээ. Хэдэн өдөр байлдсаны дараа амиа аварч, гол гатлан азаа туршихын тулд үлдсэн Гэгээнтнүүд албадагдан бууж өгчээ. Таваас зургаан зуун эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүд мөрнийг гатлан, мөрний эрэг дээр буудалласан байжээ. Ерөнхийлөгч Бригам Янг эдгээр хөөрхий Гэгээнтнүүдийг нүүлгэн шилжүүлж, аврах багийг эд зүйлсийн хамт илгээсэн байна.

18. Солт Лейкийн Ариун сүм

Хожмын Үеийн Гэгээнтэн анхны хамтлаг Солт Лейкийн хөндийд ирснээс хэдхэн өдрийн дараа Ерөнхийлөгч Бригам Янг таягаараа газар хатган “Энд бид Бурханыхаа ариун сүмийг барих болно” хэмээн мэдэгджээ. 1853 оны хоёрдугаар сарын 14-нд газар хөндөх ёслол хийгджээ. 1853 оны дөрөвдүгээр сарын 6-нд суурь нь тавигдсан байна. Ариун сүм 40 жилийн дараа 1893 онд баригдаж дуусан, онцгойлон адислагдсан ажээ. Бурханы хаант улсыг барих хийгээд үүнд үйлчлэхэд Их Эзэний зааврыг эрэлхийлэн мөн тунгаан бодохоор Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгч энд долоо хоног бүр уулзацгаадаг.

Онцгой үйл явдлууд: Их Эзэн Сүмийн Ерөнхийлөгчид болон Тэргүүн Зөвлөлүүдэд Албан тунхаг—2-ыг оролцуулан сүнсний илчлэлтүүдийг энд өгчээ. Саяхан Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Төлөөлөгчийн Зөвлөл, Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхагийг санал нэгтгэжээр зөвшөөрсөн хэвлэсэн юм. Амьд хүмүүс болон нас барагсдын аль алиных нь төлөө ариун сүмийн ёслолууд гүйцэтгэгдэж мөн сая сая хүний амьдралыг адисалсан билээ.

ГАЗРЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ

Австрали, 7:Е3 Адам-ондай Аман, Миссури, 5:Г3 Ази, 7:Е2 Албани, Нью- Йорк, 1:В3 Айова, 5:Д1, 6:Д2 Амхерст, Огайо, 3:В4 Антарктид, 7:Д4 Ариун ойн цоор- хой, Палмира- гийн бүс, 2:Б3 Арканзас гол, 6:Г3 Армингтон Сур- гуулийн зам, Палмирагийн бүс, 2:Г3 Арьс идээлэх үйлдвэр, Көртланд, 4:Б2 Атлантын далай, 1:Г4, 6:Ж2 Африк, 7:Д2 Ахмад Иосеф Найтын Гэр, Колесвилл Нью-Йоркийн Дагуул Хот, 3:Ж3 Ашери, Көртланд, 4:Б3 Бага Иосеф Сми- тийн Байшин- гийн араг яс мод, Палмира- гийн бүс, 2:Б3 Бага Иосеф Смитийн гэр, 3:Г3, 4:Б3 Бага Иосеф Сми- тийн Дүнзэн байшин, Палмирагийн бүс, 2:Б3 Бага Иосеф Сми- тийн Төрөл бүрийн бараа- ны дэлгүүр, Көртланд, 4:Б3	Бага Иосеф Смитийн Ферм, Палмирагийн бүс, 2:Б3 Банк, Көртланд, 4:Б4 Баптисмын бүс, Көртланд, 4:Б2 Бостон, Массачу- сетс, 1:Г3 Брикард, Көрт- ланд, 4:А2 Буфало, Нью- Йорк, 3:Д2 Вашингтон, Колумбын тойрог, 6:Е2 Вермонт, 1:В2 Винтер Квортерс, Индианы газар нутаг, 5:Б1, 6:Д2 Витнейн гудамж, Көртланд, 4:А3 Витингхем, Вермонт, 1:В3 Веине гүнлэг, Нью-Йорк, 2:А3, 2:В2 Галлатин, Миссури, 5:Г3 Гарден грөү, Айова 5:Г2 Гилад гол, 6:Б4 Гилсам, Нью Хампшир, 1:Г2 Гранд гол, Миссури, 5:Г2 Дам, Көртланд, 4:Б2 ДеВитт, Миссури, 5:Д3 Делавер гол, 1:Б4 Е.В.Грандины Хэвлэх үйлд- вэр, Палмира- гийн, 2:В2 Европ, 7:Д1 Ери нуур, 3:В3	Ери суваг, Нью- Йорк, 2:Б2, 3:Е1 Жон Жонсоны дэн буудал, Көртланд, 4:Б2 Жаксон гүнлэг, Миссури, 5:Г4 Иллиной, 5:Г3, 6:Е2 Индепенденс, Миссури, 5:Г4, 6:Д2 Индиана, 6:Е2 Индианы газар нутаг, 5:Б2, 6:В1, 6:Г3 Иосефын гудамж, Көртланд, 4:А4 Исаак Морлейн ферм, Көртланд, 4:Г1 Их Милл, Көртланд, 4:Б2 Их Солт Лейк, 6:Б2 Калифорни, 6:А3 Калифорнийн зам, 6:Б2 Канад, 1:В1, 3:В3, 3:Г2, 6:Е1 Канадын гол, 6:Г3 Канандаиуга зам, Палмирагийн бүс, 2:В3 Картейж, Иллиной, 5:Е2 Каудерийн гу- дамж, Көрт- ланд, 4:А3 Каунсил Блаффс (Канесвилл), Айова, 5:В1, 6:Д2 Клевленд, Огайо, 3:В4 Колесвилл, Нью- Йорк, 1:Б3, 3:Ж3 Коннектикут, 1:В3	Коннектикут гол, 1:Г1 Көртланд, Ариун сүм, 4:Б4 Көртланд, Огайо, 3:В3, 6:Е2 Кумора гүвээ, Палмирагийн бүс, 2:В4 Квинси, Иллиной, 5:Е2, 6:Д2 Лебанон, Нью Хампшир, 1:Г2 Либерти, Миссу- ри, 5:Г4, 6:Д2 Лос Анжелос, 6:А3 Манчестер хотхон, Нью-Йорк, 1:А3, 2:Г3, 3:Е2 Маркелл зам, Көртланд, 4:А2 Мартин Харрисын гэр, Көртланд, 4:Г4 Мартин Харрисын ферм, Палми- рагийн бүс, 2:Б1 Маседон хотхон, Палмирагийн бүс, 2:А1 Массачусетс, 1:В3 Мексик, 6:Б3 Мендон, Нью- Йорк, 3:Е2 Миссион Сан Луис Рей, 6:А4 Миссиппи мөрөн, 5:Е3 Миссури, 5:Е3, 6:Д3 Миссури мөрөн, 5:В2, 5:Е4 МкЛивэйний хамтлаг, Миссури, 5:Д3 Монтроз, Айова, 5:Е2 Могойт гол, 6:Б1 Мэин, 1:Г2
--	--	--	--

Найт Винсоны гэр, Көртланд, 4:А4	Палмира хотхон, Нью-Йорк, 1:А3, 2:Г1, 3:Е2	Сидней Ригдоны гэр, Көртланд, 4:Б4	Форт Ливенворт, 5:Г4, 6:Д2
Науву, Иллиной, 5:Е2, 6:Д2	Палмира тосгон, Нью-Йорк, 2:В2	Смит Алвин, булш, Палмира, 2:В2	Форт Холл, 6:Б1
Номхон далай, 6:А1, 7:А3	Парлей П.Праттын гэр, Көртланд, 4:А3	Солт Лейк Хот, 6:Б2	Фридом, Нью- Йорк, 3:Е2
Норвик, Вермонт, 1:Г2	Пекос гол, 6:В4	Спрингфилд, Иллиной, 5:Е2	Хадсон гол, Нью- Йорк, 1:В3
Нью Жерси, 1:Б4	Пеннсильвани, 1:Б3, 3:Д3, 6:Е2	Стафордрөүд, Палмирагийн бүс, 2:Б4	Хайрам, Огайо, 3:В4
Нью-Йорк, 1:Б3, 3:Е3, 6:Е1	Петтсбург, Нью- Йорк, 3:Д2	Сургууль, Көртланд, 4:Б3	Хайрум Смитийн гэр, Көртланд, 4:Б4
Нью-Йорк хот, 1:В4, 6:Е1	Писга уул, Айова, 5:Г1 Платт гол, 5:Б1	Таксон, 6:Б4	Хармони, Пеннсильвани, 1:Б3, 3:Ж3
Нью Хампшир, 1:Г2	Пуебло, 6:В3	Танбриж, Вермонт, 1:В2	Хатавай горхи, Палмирагийн бүс, 2:Б2, 2:Г4
Ньюел К.Витнейн гэр, Көртланд, 4:Б2	Рамус Иллиной, 5:Е2	Төв Америк, 7:Б2	Хаунс Милл, Миссури, 5:Г3
Ньюел К.Витнейн дэлгүүр, Көртланд, 4:Б2	Ред Крик, Палми- рагийн бүс, 2:Г2	Томпсон Огайо, 3:Г3	Хойд Америк, 7:Б2
Огайо, 3:Б4, 6:Е2	Рио Гранд гол, 6:В4	Топсфилд, Масачусетс, 1:Г3	Хойд Атлантын далай, 7:Г2
Онтарио гүнлэг, Нью-Йорк, 2:А3, 2:В3	Ричмонд, Миссури, 5:Г4	Торонто, Канад, 3:Д1	Хойд Номхон далай, 7:А2, 7:Ж2
Онтарио нуур, 1:А2, 3:Д1	Роде арал, 1:Г3	Фар Вест Миссури, 5:Г3, 6:Д2	Хойд Платте гол, 6:В2
Оранж, Огайо, 3:В4	Рочестер, Нью- Йорк, 3:Е1	Фармингтон, Пал- мира бүсийн хотхон, 2:А4	Хэвлэх Газар, Көртланд, 4:Б4
Орегоны Газар нутаг, 6:А1	Савмилл, Көртланд, 4:Б2	Фейетте, Нью- Йорк, 1:А3, 3:Е2, 6:Е1	Хюрон Нуур, 3:В1
Оршуулгын Газар, Көртланд, 4:Б3	Салем, Масачусетс, 1:Г3	Филадельфи, Пеннсильвани, 1:Б4, 6:Е2	Чагрин гол, зүүн салаа, Көртланд, 4:Б1
Өмнөд Америк, 7:В3	Сакраменто, 6:А2	Фингер нуурууд, Нью-Йорк, 1:А3, 3:Е2	Чаритон гол, Миссури, 5:Д2
Өмнөд Атлантын Далай, 7:Г4	Сан Бернардино, 6:Б3	Фишинг гол, Миссури, 5:Г3	Чилликот зам, Көртланд, 4:Б4
Өмнөд Бэйнбриж, Нью-Йорк, 3:Е3	Сан Диего, 6:А4	Фокс Рөүд, Палмирагийн Бүс, 2:А3	Шарон, Вермонт, 1:В2
Өмнөд Номхон далай, 7:А4	Сан Франциско, 6:А2	Форт Брижер, 6:В2	Шоал Крик, Миссури, 5:Г3
Өмнөд Платт гол, 6:В2	Санта Фе, 6:В3	Форт Ларами, 6:В2	Энэтхэгийн Далай, 7:Е3
	Сасквиеханна гол, Пеннсильвани, 1:А4, 3:Е3		
	Сейнт Луйс, Миссури, 5:Е4		

Дараах газрын зургууд нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн эхэн үеийн түүх болон Бошиглогч Иосеф Смит хийгээд түүнийг залгамжлагчдаар дамжуулан илчлэгдсэн судруудыг

1. НЭГДСЭН УЛСЫН ЗҮҮН ХОЙД ХЭСЭГ
2. ПАЛМИРА—МАНЧЕСТЕР, 1820–31
3. АНУ-ЫН НЬЮ-ЙОРК, ПЕННСИЛЬВАНИ БОЛОН ОГАЙО БҮС.

илүү сайн ойлгоход тань туслах болно. Судруудад өгүүлэгдсэн газар нутгийн байршлыг мэдсэнээр та судрын үйл явдлыг илүү сайн ойлгож чадна.

4. КӨРТЛАНД, ОГАЙО, 1830–38
5. АНУ-ЫН МИССУРИ, ИЛЛИНОЙ БОЛОН АЙОВАГИЙН БҮС
6. ӨРНӨД УРУУ ЧИГЛЭСЭН СҮМИЙН НҮҮДЭЛ
7. ДЭЛХИЙН ГАЗРЫН ЗУРАГ

Газруудын нэрний цагаан толгойн дараалаарх жагсаалт нь тодорхой нэг газрыг газрын зураг дээр олоход танд тусална. Тайлбар бүр газрын зургийн дугаарыг даган үсэг болон тоог хослуулсан солбилцлын заалтыг багтаасан болно. Жишээ нь: Форт Хиллын байршлыг өгөхдөө 6:Б1 гэсэн байгаа нь; Б1 гэсэн хавтгай дахь газрын зураг 6 гэсэн үг юм. Та газрын зураг бүр дээр газрын зургийн дээд талыг хажуу талтайгаа солбилцох солбилцлыг мэдсэнээр тодорхой нэг хавтгайг олж чадна. Тухайн газрын өөр нэрсийг хаалтанд жагсаасан болно; жишээ нь, Каунсил Блаффс (Канесвилл).

Дараах нь газрын зураг дээр ашигласан янз бүрийн бэлэгдэл болон бичиглэлийг ойлгох түлхүүр юм. Үүнээс гадна, газрын зураг зөвхөн тухайн газрын зурагт хамааралтай нэмэлт бэлэгдлүүдийн тайлбарыг агуулсан байж болно.


Улаан цэг нь хот буюу тосгоныг төлөөлдөг. Заримдаа тухайн цэгээс хот буюу газрын нэр уруу шугамаар заасан байдаг.

Атлантын далай Энэ бичиглэл нь далай, тэнгис, нуур, гол, уулс, цөл, хөндий, говь болон арал зэрэг газарзүйн нутаг дэвсгэрийг тодорхойлоход ашиглагддаг.

Палмира Энэ бичиглэл нь бүх хот болон тосгодын нэрэнд хэрэглэгддэг.


НЬЮ-ЙОРК Энэ бичиглэл нь орон нутаг болон Нэгдсэн Улсын муж улсууд, газар нутгууд зэрэг жижгэвтэр улс төрийн нэгжүүдэд ашиглагддаг.

КАНАД Энэ бичиглэл нь үндэстэн, улсууд болон тивүүд зэрэг томоохон улс төрийн нэгжүүдэд ашиглагддаг.




1. **Топсфиелд** 1771 оны долдугаар сарын 12-нд Ахмад Иосеф Смитийн төрсөн газар.
2. **Гилсам** 1775 оны долдугаар сарын 8-нд Люси Мак энд төржээ.
3. **Танбриж** 1796 оны нэгдүгээр сарын 24-нд Ахмад Иосеф Смит Люси Мак хоёр энд гэрлэжээ.
4. **Витингхам** Бригам Янгийн төрсөн газар, тэрээр 1801 оны зургадугаар сарын 1-нд төржээ.
5. **Хармони** 1804 оны долдугаар сарын 10-нд Хармони хотхонд Эмма Хейл төржээ.

6. **Шарон** 1805 оны арванхоёрдугаар сарын 23-нд Бага Иосеф Смит энд төржээ (ИС—Т 1:3-ыг үз).
7. **Лебанон** 1811 оноос 1813 он хүртэл Бага Иосеф Смит хөлний хүнд мээ засал хийлгэсэн тэр үед Смитийн гэр бүл Лебанон хотхонд амьдарч байв.
8. **Норвик** Палмира уруу нүүхээсээ өмнө, 1814 оноос 1816 он хүртэл Смитийн гэр бүл энд амьдарч байжээ.
9. **Палмира** 1816 онд Смитийн гэр бүл энд нүүж ирэв (ИС—Т 1:3-ыг үз).



1. **Ахмад Иосеф Смитийн дүнзэн байшин** 1823 оны есдүгээр сарын 21, 22-нд энэ байшингийн дээд давхарт тэнгэр элч Моронай Иосеф Смит дээр иржээ (ИС—Т 1:29–47-г үз).
2. **Ахмад Иосеф Смитийн ферм** 4.7 га энэ фермийг 1820 оноос 1829 он хүртэл Смитийн гэр бүл боловсруулж байв.
3. **Ариун ойн цоорхой** 1820 оны хаврын эхэнд энэ ойд Иосеф Смитийн Анхны Үзэгдэл тохиожээ (ИС—Т 1:11–20).
4. **Ахмад Иосеф Смитийн дүнзэн байшин** 1822 онд Энэ байшинг Алвин Смит эхлүүлсэн бөгөөд Смитийн гэр бүл 1825 оноос 1829 онд амьдарч байв.
5. **Кумора гүвээ** 1827 оны есдүгээр сарын 22-нд энд тэнгэр элч Моронай Иосеф Смитэд алтан ялтсуудыг өгчээ (ИС—Т 1:50–54, 59-ийг үз).
6. **Мартин Харрисын ферм** Энэ фермийг барьцаанд тавьж, мөн хагасыг нь Мормоны Номыг хэвлэхийн тулд худалджээ.
7. **Е. В. Грандины хэвлэх үйлдвэр** Энд 1829–30 онд Мормоны Ном 5000 хувь хэвлэгджээ.
8. **Хатавай горхи** Энэ горхинд Сүмийн анхны баптисмууд гүйцэтгэгджээ.



- 1. Өмнөд Бэйбриж** Бага Иосеф Смит Эмма Хейл хоёр 1827 оны нэгдүгээр сарын 18-нд энд гэрлэжээ (ИС—Г 1:57-г үз).
- 2. Колесвилл** 1830 онд Колесвилл хотод Ахмад Иосеф Найтын гэрт Сүмийн анхны салбар зохион байгуулагдсан.
- 3. Хармони дахь Бага Иосеф Смитийн байшин** Мормоны Номны ихэнх орчуулга энд дуусчээ. 1829 онд Сасквеханна голын эрэгт саннаар сэргээгджээ (С ба Г 13; 128:20; ИС—Г1:71-72).
- 4. Фейетте** Гураван гэрт алтан алтсууд болон тэнгэр элч Моронайг харжээ (С ба Г 17). 1829 оны зургадугаар сард Мормоны Номны орчуулга энд дуусав. 1830 оны

- дөрөвдүгээр сарын 6-нд энд Сүм зохион байгуулагджээ (С ба Г 20; 21).
- 5. Мендон** Бригам Янг Хибер СКМбали хоёр эхний үед амьдарч байсан байшин.
- 6. Көртланд** Леменүүд уруу илгээсэн номлогчид 1830 онд энд буудаллаж Сидней Ригдон болон Көртландын бусад бусад хүмүүст багтис хүртээв. 1831 оноос 1838 он хүртэл энэ нь Сүмийн төв захиргаа байжээ. Энэ эрин үеийн анхны ариун сүм Көртландад баригдаж мөн 1836 оны гуравдугаар сарын 27-нд ондг облон адислагдсан ажээ (С ба Г 109-ийг үз).
- 7. Ери Суваг** 1831 оны тав, зургадугаар сард Ери суваг болон Ери нуураар дамжин Нью-Йоркийн гурван салбар Огайотгийн Көртланд уруу цагаачилжээ.

- 8. Хайрам** 1831 оны есдүгээр сараас 1832 оны есдүгээр сар хүртэл Иосеф Эмма хоёр энд амьдарч байв. Иосеф Сидней Ригдон хоёр Иосеф Смитийн Библийн Орчуулган (ИСО) дээр ажиллаж байв. Энд хүүлэн авалдсан илчлэлтүүд: С ба Г хэсэг 1, 65, 67, 68, 69, 71, 73, 74, 76, 77, 79, 80, 81, 99, 133.
- 9. Амхерст** 1832 оны нэгдүгээр сарын 25-нд Иосеф Смит Дээд саннаартны Ерөнхийлөгчөөр багтгадгав (С ба Г 75-ыг үз).
- 10. Торонто** Сүмийн гурав дахь ерөнхийлөгч Жон Тейлор, мөн Хайрум Смитийн эхнэр Мари Фийлдинг Смит нарын төрөөх нутаг.




1. **Ньюел К.Витнейн байшин** 1831 онд Көртландад анх нүүж ирснийхээ дараа Иосеф Эмма хоёр энд хэдэн долоо хоног амьдарч байжээ.
2. **Исаак Морлейн ферм** 1831 оны гуравдугаар сараас есдүгээр сар хүртэл Иосеф, Эмма Смит хоёр энд амьдарч байжээ. Анхны дээд санваартнууд энд томилогджээ. Иосеф Смитийн Орчуулган (ИСО) дээр Иосеф ажиллаж байв.
3. **Ньюел К.Витнейн дэлгүүр** Сүмийн Тэргүүн Зөвлөлд хаант улсын түлхүүрүүд энд өгөгджээ. Бошиглогчдын Сургууль анх энд эхэлсэн байна. 1833 онд ИСО энд дуусах шатандаа орж байв. 1832 оноос 1833 онд Иосеф Эмма хоёр энд амьдарч байв. Энд Иосеф олон илчлэлт хүлээн авчээ.
4. **Жон Жонсоны дэн буудал** 1833 онд энд Ахмад Иосеф Смит Сүмийн анхны патриархаар дуудагджээ. Дэн буудалд Көртландын анхны хэвлэх үйлдвэр багтдаг байв. Миссурийн Жаксон гүнлэгийн хэвлэх үйлдвэр сүйрсний дараа *The Evening and the Morning Star* энд хэвлэгдэж байв. 1835 оны тавдугаар сарын 4-нд Арванхоёр Төлөөлөгч анхныхаа номлолд эндээс явцгаажээ.
5. **Ахмад Иосеф Смитийн байшин** 1834 оноос 1837


он хүртэл Иосеф Эмма хоёр энд амьдарч байв. Абрахамын номны орчуулга эхэлжээ.

6. **Хэвлэх үйлдвэр** Итгэлийн лекцүүд энэ байшинд өгөгджээ. Арванхоёр Төлөөлөгч болон Далын Нэгдүгээр Чуулга энд дуудагдаж мөн томилогдов. Сургаал ба Гэрээ (1 дэх хэвлэл), Мормоны Ном (2 дахь хэвлэл), *The Evening and the Morning Star*, *Latter Day Saint's Messenger and Advocate*, мөн *Elders' Journal*-ын анхны дугаарууд энд хэвлэгджээ.
7. **Көртландын Ариун сүм** Энэ ариун сүм нь энэ эрин үеийн анхных байв. Есүс Христ хүрч ирэн, ариун сүмийг хүлээн зөвшөөрчээ. Мосе, Елиас болон Елиа нар хүрч ирэн, зарим санваарын түлхүүрүүдийг сэргээжээ (С ба Г 110-ыг үз). Бошиглогчдын сургууль энд хичээллэж байв. Энд хүлээн авагдсан илчлэлтүүд: С ба Г хэсэг 109, 110, 137.

Көртланд (тодорхой бус газар) 1835 оны наймдугаар сарын 17-нд Сургаал ба Гэрээг судар хэмээн хүлээн авчээ. Көртландад хүлээн авагдсан судруудад С ба Г хэсэг 41–50, 52–56, 63–64, 102–104, 106–110, 134 болон 137 багтана. Хэсэг 104 нь нэгдсэн журамд оролцож буй Сүмийн гишүүд зарим эд хөрөнгөө өргөл болгон барихыг сургадаг (шүлэг 19–46-г үз).




- 1. Инделленс** Слонь төв газар байхаар тогтоолжээ (С ба Г 57:3-г үз). 1831 оны наймдугаар сарын 3-нд арвун сүмийн газар онц ойлон адислагдав. 1833 онд Гэгээнтнүүд эндээс хөөгдсөн ажээ.
- 2. Фишинг Ривер** 1834 онд Жаксон гүнзлэгийн Гэгээнтнүүдийг нутагт нь сэргээжээр Иосеф Смит болон Сионы Хуаран Огайогийн Кортландас Миссури уруу явжээ. С ба Г 105-энэ толын эрэг дээр илчлэгджээ.
- 3. Фар Вест** Энэ нь Миссури дэх Мормоны хамгийн том суурин байв. Ариун Сүмийн газар энэ газар дээр онцгойлон адислагджээ (С ба Г 115-ыг үз). 1838 оны долодугаар сарын 8-нд Британий Ариундэд номлолд үйлчлэх дуудлагыг Их Эзэнээс Арванхоёрын Чуулга хүлээн авчээ (С ба Г 118-ыг үз).
- 4. Адам-ондай-Аман** Миссурийн дээд хэстийн энэ газрыг Есүс Христ, Адам болон түүний зөв шударга үр удамтай уулахаар ирэхэд агуу цугларалтын газар болно хэмээн Их Эзэн мэдэгджээ (С ба Г 78:15; 107:53-57; 116-ч үз).
- 5. Либертийн шорон** 1838 оны арванхоёрдугаар сараас 1839 оны дөрөвдүгээр сар хүртэл Иосеф Смит болон бусад хүмүүс зүй бусаар хоригдов. Сүмд хүнд хэцүү байсан үеийн дунд үед Иосеф Их Эзэнээс илчлэл хүсч С ба Г хэсэг 121-123-ыг хүлээн авчээ.
- Навуу** Миссури мөрөн дээр байрладаг энэ газар 1839 оноос 1846 он хүртэл Гэгээнтнүүдийн цугларалтын газар байв. Энд арвун сүм баригдаж мөн нас баргсдын төлөөх багтисм, хишиг хүргээлт болон гэр булүүдийн лашдалт зэрэг ёслолууд эхэлсэн байна. 1842 онд Халамжийн нийгэмлэг зохион байгуулагджээ. С ба Г хэсэг 124-129 хүртэлх илчлэлтүүд энд хүлээн авадсан ажээ.
- Каргейж** 1844 оны зургадугаар сарын 27-нд Бошиглогч Иосеф Смит, түүний ах Хайрум хоёр алагджээ (С ба Г 135 г үз).
- Винтер Квортс** Гэгээнтнүүд Солт Лейксийн хөндий уруу явах зам дахь суурьшлын төв (1846-1848). Израйлын Буудал өрнөд тийш аялах замд зохион байгуулагджээ (С ба Г 136).
- Каунсел Блаффс** (Канесвилл) 1847 оны арванхоёрдугаар сарын 27-нд Еронхийлогч Бригам Янгийн хамт Тэргүүн Зөвлөл багтлагджээ.



1. Фейетте Бошиглогч Иосеф Смит 1831 оны нэгдүгээр сард Фейеттегээс Көртланд Огайо уруу явжээ. Их Эзнийн цуглар гэсэн зарлигийн дагуу Нью-Йоркийн гураван салбар 1831 оны дөрөв, тавдугаар сард араас нь явжээ (С ба Г 37, 38-ыг үз).
2. Көртланд 1831 оны хоёрдугаар сарын 1-нээс 1838 оны нэгдүгээр сарын 12-нд Бошиглогчийг Миссурийн Фар Вест уруу нүүх хүртэл Сумийн захиргааны гол төв байжээ.
3. Индепенденс 1831 оны долдугаар сард Их Эзэн Индепенденсийг (Миссурийн Жаксон гүнзэг) Сионы төв газар хэмээн тогтоожээ (С ба Г 57,3). 1833 оны арваннэгдүгээр сард танхайрагчид Гэгээнтнүүдийг Жаксон гүнзэгээс гарамж шаардсанав.
4. Либэрти Жаксон Гүнзэгээс ирсэн Гэгээнтнүүдийг явхимг дахин шаардахад, тэд 1833 оноос 1836 он хүртэл Клей Гүнзэгт буларчээ. Бошиглогч Иосеф Смит болон бусад хүмүүс энд шоронд хоригдож байжээ.
5. Фар Вест 1836 оноос 1838 он хүртэл энэ нь Гэгээнтнүүдэд хоргодох байр болжээ. 1838 онд энэ нь Сумийн захиргааны гол төв байв. 1838-1839 онуудад Гэгээнтнүүд албадуулж Иллиной уруу зугтжээ.
6. Науу 1839-1846 онуудад Сумийн захиргааны гол төв байжээ. Бошиглогч Иосеф Смит болон түүний ах Хайрүм нарыг алуулсны дараа Гэгээнтнүүд өрнөд уруу нүүв.
7. Каунсел Блаффс 1846 онд анхдагч нар энд хүрч ирэв. 1846 оны долдугаар сарын 21-нд Мормоны сумангийн гишүүд Жеймс Аллену удирдлага дор явжээ.
8. Винтер Квортэрс 1846-1848 онуудад Сумийн захиргааны гол төв байв. 1847 оны дөрөвдүгээр сард Ерөнхийлөгч Бригам Янгийн удирдлага дор тэргүүтлэх бүтэг өрнөд уруу хөдөлжээ.
9. Форт Ливенворт 1846 оны наймдугаар сард өрнөд уруу аялж эхлэхээс өмнө Мормоны суман энд бүх эзллийг бэлтгэсэн байв.
10. Санта Фе 1846 оны арвадугаар сарын 19-нд эцдээс явган маршар хөдөлсөн Мормоны суманг Филип Күүк захирч байв.
11. Пуэбло Өвчтэй гураван пэргийг элдгэхийн тулд тэднийг Пуэбло руу илгээсэн бөгөөд тэнд тэд 1846-1847 оны өвлийг Миссиппээс ирсэн Гэгээнтнүүдийн хамт өнгөрүүдгээ. Эдгээр бүлэг хүмүүс Солт Лейкийн хөндийд 1847 оны долдугаар сард иржээ.
12. Сан Диего 1847 оны нэгдүгээр сарын 29-нд Мормоны суман 3200 километр явган аялж энд хүрч ирэв.
13. Лос Анжелес 1847 оны долдугаар сарын 16-нд энд Мормоны суман халагджээ.
14. Сакраменто Сумангийн халагдсан зарим гишүүд энд ажиллаж байсан бөгөөд Америкийн голын зүүн толгой цаана Сатерн Уорхайд алт илрүүлэхэд тусалж байв.
15. Солт Лейк Хот 1847 оны долдугаар сарын 24-нд Бригам Янг Солт Лейкийн хөндийд хүрч иржээ.





1. Ойн Ариун Цоорхой Бошиглогч Иосеф Смит гэрийнхээ ойролцоох энэ ойд Анхны Үзэгдлийг харсан байна.




2. Кумора Гүвээ болон Манчестер, Палмирагийн Бүс Тэнгэр элч Моронай энэ гүвээнд өөрийнхөө нуусан алтан ялтсуудыг олоход нь Иосеф Смитэд зааварчилжээ. (Гүвээ баруун төв хэсэгт байна.)



3. Ахмад Иосеф Смитийн дүнзэн байшин Энэ бол Смитийн гэр бүл нэгэнтээ амьдарч байсан байшингийн хувилбар.



4. Грандины дардсын болон хэвлэх үйлдвэр Энд Мормоны Номыг анх удаа хэвлэжээ.



5. Сасквиеханна гол Аароны болон Мелкиздекийн санваар энэ голын эрэг дээр сэргээгджээ (С ба Г 13; 128:20-ийг үз).



6. Ахмад ПЕТР Витмерийн дүнзэн байшин 1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд Сүм зохион байгуулагдсан газар дээр энэ хувилбар баригджээ.



7. Ньюел К.Витнейн болон Компанийн дэлгүүр Мэргэн Ухааны Үг (С ба Г 89-ийг үз) хэмээгддэг илчлэлт болон бусад илчлэлтүүд энд хүлээн авагджээ.



8. Жон Жонсоны гэр Энэ гэрт Библийн орчуулга дээр ажиллаж байхдаа Бошиглогч Иосеф Смит Сидней Ригдон хоёр Сургаал ба Гэрээний 76-д бичигдсэн илчлэлт мөн бусад илчлэлтүүдийг хүлээн авчээ.



9. КӨРТЛАНДЫН АРИУН СҮМ Энэ эрин үед, 1836 онд баригдсан анхны ариун сүм. Энэ ариун сүмд Есүс Христ, Мосе, Елиас, Елиа нар хүрч ирэн санваарын түлхүүрүүдийг сэргээжээ (С ба Г 110-г үз).



10. АДАМ-ОНДАЙ-АМАНЫ ХӨНДИЙ Энд Адам болон түүний зөв шударга үр удам уулзжээ (С ба Г 107:53–57-г үз). Адам, мөн бусад бошиглогчид хийгээд үе үеийн итгэлтэй Гэгээнтнүүд Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн үед энд түүнтэй уулзах болно.



11. Фар Вестийн Ариун сүмийн газар 1838 онд энд ариун сүм барихыг Их Эзэн Гэгээнтнүүдэд зарлиглажээ (С ба Г 115:7–8-ыг үз). Танхайрагчдын мөрдлөг хавчлага үүнийг хийхэд нь тэдэнд саад болсон юм.



12. Либертийн шорон Бошиглогч Иосеф Смит хилсээр энд хоригдож байхдаа эдүгээ Сургаал ба Гэрээний 121–123-т бичигдсэн илчлэлтийг хүлээн авсан байна.



13. Науву дахь Ордон гэр 1843 оны эхнээс Бошиглогч Иосеф Смитийн гэр бүл амьдарч байсан байшин. Сүмийн эхний үед Гэгээнтнүүдийн дундах олон нийтийн төв байжээ.



14. Бошиглогч Иосеф Смитийн улаан тоосгон дэлгүүр 1842 оны гуравдугаар сарын 17-нд Халамжийн Нийгэмлэг энэ байшинд зохион байгуулагджээ.



15. Наувугийн Ариун сүм Энэ загвар нь 1848 онд шатаагдахаас өмнөх эх барилгын гоо үзэмжийг харуулжээ.



16. Картейжийн шорон 1844 оны зургадугаар сарын 27-нд Бошиглогч Иосеф Смит, түүний ах Хайрум хоёр энд алагджээ (С ба Г 135-ыг үз).



17. Вестээс гарсан нь 1846 оны хоёрдугаар сарын 4-нд анхны тэрэгнүүд Миссиссиппи Мөрнийг гаталж, өрнөд уруу хийсэн түүхэн аянаа эхэлжээ.



18. Солт Лейкийн Ариун сүм Солт Лейкийн хөндийд энэхүү бүтээн босгох үйл явц 40 жил үргэлжилжээ.

БИБЛИЙН ГАЗРЫН
ЗУРАГ БОЛОН
ГЭРЭЛ ЗУРГУУД

Эдгээр гэрэл зургуудыг Есүсийн амьдарч байсан газар нутаг, библийн бошиглогчдын амьдарч байсан болон зааж байсан судрын олон үйл явдал болж өнгөрсөн чухал газруудаас жишээ болгон авсан юм. Судлах явцдаа гэрэл зургуудыг илүү сайн ашиглахад тань туслахын тулд гэрэл зураг бүрд бага хэмжээний тайлбаруудыг хавсаргасан болно. Тайлбарын дугаар болон гарчиг нь зургийн дугаар болон гарчигтай

адил юм. Тайлбарын нэрний дараах эхний догол мөр нь гэрэл зургийн байдлыг, түүний дотор харвал зохих чухал зүйлүүд хийгээд гэрэл зураг хаашаа харсныг олон-таа тайлбарласан байдаг. Дараа нь судрын чухал үйл явдлуудын талаар илүү их зүйлийг та нар хаанаас уншиж болохыг мэдэхийн тулд тухайн нутагт болсон үйл явдлуудыг судрын ишлэлүүдийн хамт жагсаасан болно.

1. Нил мөрөн ба Египет

Нил мөрний эргээр ургасан ургамал. Цаад талд нь Египетийн ихэнх хэсгийг эзэлдэг элсэн цөл байдаг.

Онцгой үйл явдлууд: Энэ газар нутгийг Египетчүүд нээн олжээ (Абр. 1:23–25). Абрахам Египет уруу явсан байна (Эхл. 12:10–20; Абр. 2:21–25). Иосеф Египетэд худалдагдаж, удирдагч болж, мөн гэр бүлээ өлсгөлөнгөөс аварчээ (Эхл. 37; 39–46). Иаковын үр удам Египетэд амьдарч байв (Эхл. 47; Ег. 1; 12:40). Фараогийн охин нялх Мосег голоос олж, түүнийг өсгөн хүмүүжүүлжээ (Ег. 2:1–10). Израилчуудыг Египетээс гарахад нь Мосе удирдсан юм (Ег. 3–14). Херодоос түр зуур зугтахын тулд Мариа, Иосеф, Есүс нар Египет уруу явжээ (Мат. 2:13–15, 19–21). Эцсийн өдрүүдэд египетчүүд Их Эзэнийг мэдэх бөгөөд Их Эзэн Египетийг адислах болно (Иса. 19:20–25). (Судруудын удирдамж, Египетийг үз)

2. Синай уул (Хороб) болон Синайн цөл

Энэ уулсын оргил нь Иебел Муса, Мосегийн Уулын шовх оргил юм. Синай уул байж болох хэд хэдэн газар байдаг. Хамгийн ихээр таамаглаж буй газрын нэг нь Иебел Муса юм.

Онцгой үйл явдлууд: Бурхан Мосе дээр ирж түүнд Арван Зарлигийг өгчээ (Ег. 19–20). Мосе, Аарон, Аароны хоёр хүү мөн 70 ахлагч Бурханыг харж мөн түүнтэй ярилцжээ (Ег. 24:9–12). Бурхан Мосед асар барих заавар өгөв (Ег. 25–28; 30–31). Израилчууд алтан тугал шүтэн бишэрч, Аароныг хий хэмээн ятгасан ажээ (Ег. 32:1–8). Хатан хаан Иезебелийн амьдарч байсан Иезреел хөндийгөөс энэ нутагт Елиа зугтан иржээ (Хаад. дээд 19:1–18). Энэ нь тэрчлэн Елиа Бурхантай ярилцсан тэрхүү газар билээ (Хаад. дээд 19:8–19).

3. Иудейн цөл болон Сөнөсөн тэнгис

Иудейн цөл нь зүүн урагш үргэлжилсэн байдаг. Цаад талд нь харагдаж буй нь Сөнөсөн тэнгис юм.

Онцгой үйл явдлууд: Иудейн цөл нь эртний түүхийн олон үед маш чухал хоргодох газар байсан юм. Давид Саул Хаанаас нуугджээ (1 Сам. 26:1–3). Есүс 40 өдөр 40 шөнө мацаг барив (Мат. 4:1–11; Марк 1:12–13). Ганцаар яваа аялагчид тэр газар дайралтанд өртөхөд амархан байсан учраас Есүс сайн самари хүний тухай сургаалт зүйрлэлдээ Иудейн цөлөөр дамжин Иерусалимаас Иерихо хүртэлх замыг ашигласан ажээ (Лук 10:25–37). (Судруудын удирдамж, Сөнөсөн Тэнгисийг үз)

4. Кадеш-барне

Энэ бол Кадеш-барне оршдог их цөлийн хөндийн зүүн хойд хэсэг. Борооны улиралд үүгээр урсдаг гол Зиний хөндийг сайн услагдсан үржил шимтэй болгодог.

Онцгой үйл явдлууд: Канааны нутгийг олуулахаар Мосе 12 эрэгтэйг энэ газраас явуулсан байж болзошгүй (Тоол. 13:17–30). Израилчууд 40 жил цөлд хэрэн тэнүүчилсэн 38 жилийнх нь турш энэ газар гол буудал нь байжээ (Дэд хууль 2:14). Мириам энд нас барж мөн оршуулагджээ (Тоол. 20:1). Энэ нь Корагийн эсэргүүцэл, хүмүүсийн бувтнаан хийгээд Аароны саваа нахиалсан талбар байв (Тоол. 16–17). Үүний ойролцоо Мосе хад хагалж ус гаргажээ (Тоол. 20:7–11).

5. Патриархуудын бунхан

Бүх Ариун газрын хамгийн алдартай барилгуудын нэг. Гэр бүлийнхээ шарил тавих газар байхаар Абрахамын худалдан авсан уламжлалт газар болох Махпелагийн агуйн дээд талд, Хебронд Хаан Херод үүнийг баруулсан ажээ (Эхл. 23).

Онцгой үйл явдлууд: Сара (Эхл. 23) Абрахам (Эхлэл 25:9) хоёрын бунхны газар. Исаак, Ребека болон Леа тэргэлтэн энд оршуулагджээ (Эхл. 49: 30–31). Иаковын цогцсыг Египетээс Канаанд авчирч агуйд оршуулжээ (Эхл. 50).

6. Иудейн уулархаг нутаг

Иудейн уулархаг нутаг нь ойролцоогоор 56 километр урт, 27 километр өргөн. Ихэнх газар нь чулуурхаг бөгөөд боловсруулахад хэцүү. Зөвхөн хөндийнүүдээр тусгаарлагдсан өндөр толгод л үржил шимтэй. Эртний израилчууд эдгээр толгодод амьдарч байсан бөгөөд булаан эзлэгчдээс хамгаалахад тэдгээрийг ашигладаг байжээ. Иерусалим энэ бүсэд оршдог.

Онцгой үйл явдлууд: Абрахам болон түүний үр удамд Их Эзэн энэ нутгийг амлажээ (Эхл. 13:14–18; 17:8). Өнөөгийн Хеброн дахь Махпелагийн агуйд Сара Абрахам хоёрыг оршуулжээ (Эхл. 23:19; 25:9). Давид иебучуудаас Иерусалимыг булаан авчээ (2 Сам. 5:4–9). Хуучин Гэрээний ихэнх үйл явдлууд бусад газруудаас илүүтэйгээр эдгээр толгод болсон хэмээн тэмдэглэгджээ.

7. Бетлехем

Энэ гэрэл зураг хадат толгод болон урд талд нь хоньчдын билчээр, ард талд нь орчин үеийн хот Бетлехемийг харуулжээ.

Онцгой үйл явдлууд: Рахель үүний ойролцоо оршуулжээ (Эхл. 35:16–20). Рут, Боаз хоёр энд амьдарч байв (Рут 1:19–2:4). Давид Хаан энд төрж мөн хаан байхаар адислагджээ (1 Сам. 16:1–13). Аврагч энд төрж, хоньчид болон Мэргэн хүмүүс түүнд мөргөв (Мат. 2:1–11; Лук 2:4–16). (Судруудын удирдамж, Бетлехемийг үз)

8. Иерусалим

Умард зүг рүү харжээ. Зургийн голд Чулуун бөмбөгөр оройт хэмээн нэрлэгддэг алтарт бүрсэн бөмбөгөр оройтой лалын шашинтны бунхан байдаг. Энд байдаг ариун сүмүүдэд иудейчүүд эртнээс мөргөсөөр иржээ. Чулуун бөмбөгөр оройтын ойролцоох хэрмийг хуучин Иерусалимыг тойруулан босгожээ. Хэрэмний баруун талд Кидроны хөндий байна. Баруун талд нилээд хол харгаж байгаа нь Чидуны Уул юм. Хойд талд нь Чулуун бөмбөгөр оройтын ар талд Голгота буюу Калвари байж болзошгүй.

Онцгой үйл явдлууд: Эрт үед Иерусалим Салем хэмээн нэрлэгддэг байв (Дуул. 76:2).

Абрахам Мелкизедект аравны нэг төлдөг байжээ (Эхл. 14:18–20). Абрахам Исаакийг тахилд өргөхөөр иржээ (Эхл. 22:2–14). Давид Хаан Иерусалимыг иебучуудаас булаан авчээ (2 Сам. 5:4–9). Соломон Хаан ариун сүм барив (Хаад. дээд 6–7). Лихай амлагдсан нутагт очихоор явав (1 Ниф. 1:4; 2). Аврагч тохинуулж, бидний нүглийг цагаатгаж, мөн дахин амилжээ (Мат. 21–28). Аврагчийн бошигсноор түүний үхлийн дараа удалгүй Иерусалим Устгагджээ (ИС—М 1:3–20). Эцсийн өдрүүдэд Иерусалим булаан эзлэгдэх болно (Езек. 38–39; Иоел 2–3; Илч. 11; 16). Хоёр дахь Ирэлтийн өмнөхөн Аврагч энд хүрч ирэх болно (Зек. 12–14; С ба Г 45:48–53). (Судруудын удирдамж “Иерусалим”, “Салем”-ыг үз)

9. Херодын Ариун сүм

Энэ гэрэл зурагт мэ 67 онд ийм байсан хэмээн хүмүүсийн таамагласан Херодын ариун сүмийн багасгасан загварыг үзүүлжээ. Ариун сүмийг бүхлээр нь тойруулсан хэрмэн дотор Ариунаас Ариун газар, Ариун газар болон гурван их чулууг багтаасан дуган байдаг.

Онцгой үйл явдлууд: Иосеф, Мариа хоёр нялх Есүсийг ариун сүмд авчирчээ (Лук 2:22–38). Аврагч 12 настай байхдаа ариун сүм дотор заав (Лук 2:41–46). Аврагч мөнгө хүүлэгчдийг ариун сүмээс хөөж, (Мат. 21:12–13) мөн ариун сүмийн устгалын талаар бошиглов (Мат. 24:1–2). Ирээдүйн ариун сүм Иерусалимд баригдах болно (Езек. 40–48; Зек. 8:7–9). (Судруудын удирдамж “Ариун Сүм”, “Их Эзэний өргөөг” үз)

10. Ариун Сүмийн довжоо

Ариун сүм нь хашаануудад хуваагддаг бөгөөд гаднах хашаанууд нь хамгийн намхан газарт байрладаг. Сүсэгтнүүд хэд хэдэн хаалгаар, ялангуяа энэ довжоонуудаар дээш өгсөн гаднах хашаанд, цаашилаад доторх хашаанд ордог байжээ. Олон жилийн турш энэ довжоонуудаар мянга мянган хүмүүс дээш өгссөний нэг нь Бурханы Хүү юм. мэ 70 онд Титийн цэргүүд ариун сүмийг нураахад довжоонууд нурангид даргаджээ. Тэдгээр нь хуучин Иерусалим хотын хэсгийг малтах үеэр ил гарч иржээ.

Онцгой үйл явдал: Ирээдүйн ариун сүмийн хэмжээ болон хэлбэрийг Езекиел үзэгдэлд харжээ (Езек 40). (Судруудын удирдамж, “Ариун Сүм” “Их Эзэний өргөөг” үз)

11. Чидуны Уул, Оорсон Хайдын цэцэрлэг

Иерусалим уруу харсан Чидуны уулан дээрх Оорсон Хайдын Цэцэрлэгийг баруун хойноос нь харуулсан ажээ. Чидуны уулын баруун талын хажуу талд Гетсеманийн цэцэрлэг байна. 1841 оны аравдугаар сарын 24-нд Ахлагч Оорсон Хайд Чидуны ууланд очиж, Абрахамын хүүхдүүд буцаж ирэх хийгээд ариун сүм барих онцгой адислалын төлөө бошиглолын залбирал хийжээ.

Онцгой үйл явдлууд: Аврагчийн угтан хэлснээр ромчууд Иерусалимыг мэ 70 онд устгажээ (ИС—М 1:23-ийг үз). Аврагч бүх дэлхийд үзэгдэхээсээ өмнө мөн Чидуны ууланд дээр зогсох болно (Зек. 14:3–5; С ба Г 45:48–53; 133:19–20; Судруудын удирдамж, “Чидуны Уул”-ыг үз).

12. Гетсеманийн цэцэрлэг

Энэ зураг дээрх хөгшин чидуны модыг Гетсеманийн цэцэрлэг байсан хэмээн ам дамжин яригдаж ирсэн газарт авсан ажээ. Аврагч өөрөөс нь урвасан шөнө, дээд давхрын өрөөнөөс гарч явсныхаа дараа үүний ойролцоо залбирчээ.

Онцгой үйл явдлууд: Энд Есүс Христ хүн төрөлхтний нүглүүдийн төлөө зовж эхэлжээ (Мат. 26:36–44; Марк 14:32–41; С ба Г 19:16–19). Залбирсных нь дараа Искаротын Иудас түүнээс урваж, цэцэрлэгт түүнийг баригдсан дараа шавь нар нь түүнийг түр зуур орхин явжээ (Марк 14:50). (Судруудын удирдамж, “Гетсемани”-г үз)

13. Голгота

Энэ чулуу гавлын ястай төстэй бөгөөд Иерусалимын Дамаскийн хаалганы яг гадна талд байдаг. Энэ нь Есүс Христ цовдлогдсон газар байж болзошгүй.

Онцгой үйл явдал: Есүс ташуурдуулж мөн шоглуулсныхаа дараа гавлын ясан газар буюу Голгота хэмээн нэрлэгддэг газар ирэн цовдлогджээ (Мат. 27:26–35; Иохан 19:17–18). (Судруудын удирдамж, “Голгота”-г үз.)

14. Булшны цэцэрлэг

Энэ бол Аврагчийг оршуулсан гэж ам дамжин яригдаж ирсэн газар юм. Орчин үеийн хэд хэдэн бошиглогч Аврагчийн цогцсыг энэ булшны цэцэрлэгт тавьсан гэж үздэг.

Онцгой үйл явдлууд: Аврагчийг загалмай дээр нас барсны дараа түүний цогцсыг ха-

дыг янзлан хийсэн булшны газар тавьсан байна (Мат. 27:57–60). Гурван өдрийн дараа хэд хэдэн эмэгтэйчүүд булшин дээр очиж Аврагчийн цогцос тэнд байхгүйг олж мэджээ (Мат. 28:1; Иохан 20:1–2). Төлөөлөгч Петр Иохан хоёр тэрчлэн булшин дээр очиж Аврагчийн цогцос тэнд байхгүйг олж мэдсэн байна (Иохан 20:2–9). Амилсан Аврагч Магдалын Мариа дээр хүрч иржээ (Иохан 20:11–18).

15. Иерихо

Энэ гэрэл зурагт өнөө үеийн Иерихогийн өвс ургамлыг үзүүлжээ. Эрт үед энэ нь далайн түвшнээс доош 252 метрт оршдог Иордан голын хөндийд байдаг хэрмээр хүрээлэгдсэн хот байжээ. Усан үзэм болон нимбэг боловсорч цэцэглэдэг энэ газар хөдөө аж ахуйн асар их өгөөжтэй нутаг юм. Ар талд нь Уруу таталтын уул байна (Мат. 4:1–11).

Онцгой үйл явдлууд: Энэ газрын ойролцоо Иошуа болон Израилын хүүхдүүд анх удаа Иордан голыг гаталж амлагдсан нутагт ирсэн юм (Иош. 2:1–3; 3:14–16). Израилчуудыг хүч түрэн дайрахын өмнө Их Эзэн хэрэмнүүдийг гайхамшигтайгаар нурахаар болгожээ (Иош. 6; мөн Евр. 11:30-ийг үз). Иошуа хотыг зүхэж (Иош. 6:26), энэ нь гүйцэлдсэн байна. (Хаад. дээд 16:34). Елиша Иерихогийн усанд эдгэрчээ (Хаад. дэд 2:18–22). Аврагч Иерусалимд очих сүүлчийнхээ явалтаар үүгээр дайран өнгөрч, хараагүй Бартимайг эдгээж, татвар хураагч Закхайнд хоножээ (Марк 10:46–52; Лук 18:35–43; 19:1–10). Иерусалимаас Иерихо хүрдэг зам сайн самари хүний тухай сургаалт зүйрлэлд гардаг (Лук 10:30–37).

16. Шило

Баруун тийш харсан эртний хотын энэ балгас нь зурагны төвөөс ялигүй зүүнтэй байна. Тэдгээр нь өндөр толгодоор хүрээлэгдсэн бага зэрэг дугуйрсан жижиг толгод дээр байрладаг.

Онцгой үйл явдлууд: Израилын овгууд цугларч мөн өөрсдөдөө ноогдсон газар нутгийг хүлээн авчээ (Иош. 18–22). Асар болон гэрээний авдар энд тавигдаж олон зууны турш үлдсэн байна (Иош. 18:1). Энд Ханна залбирч мөн хүү Самуелаа Их Эзэний үйлчлэлд зориулсан билээ (1 Сам. 1). Израилчууд авдрыг Шилогоос авч, тэгээд авдрыг булаан авсан филистчүүдэд ялагджээ (1 Сам 4:1–11).

17. Геризим уул ба Ебал уул

Баруун талаас нь харуулжээ. Зүүн талынх нь Гризим уул, баруун талынх нь Ебал уул юм. Энэ гэрэл зурагт орчин үеийн Наблус хотыг авчээ. Эртний хот Шекем энэ хоёр уулын дунд доор харагдах хөндийд оршдог байжээ (зурагны дөнгөж баруун талд).

Онцгой үйл явдлууд: Абрахам Шехемд буудаллажээ (Эхл. 12:6–7). Иаков энд буудалдаж мөн хэсэг газар худалдаж авсан байна (Эхл. 33:18–20). Геризим уул адислалын уул, Ебал уул зүхлийн уул байв (Дэд хууль 27–28). Ебал уулан дээр Иошуа Мосегийн хуулийг агуулсан хөшөө босгож, хуулийг израилчуудад уншиж өгчээ (Иош. 8:30–35). Иосефын ясыг Шехемд оршуулжээ (Иош. 24:32).

18. Самари дахь Дотан

Ариун газрын энэ бүс нутаг нь уулын хяр болон хөндийнүүдээр тодорхойлогддог. Энэ бол үржил шимтэй хэсэг газар. Израилчууд энд суурьших үед энэ бүс нутаг Манассед өгөгджээ.

Онцгой үйл явдлууд: Дотаны хөндийд Иосеф Египетэд худалдагдсан ажээ (Эхл. 37:12–28). Иезебел Израилын бошиглогчдыг алахыг оролдоход Обадиа зуун бошиглогчийг агуйнуудад нуужээ (Хаад. дээд 18:13). Их Эзэн гайхамшигтайгаар аварсан Елиша болон түүний зарцыг Сирийн цэрэг бүсэлжээ (Хаад. дэд 6:13–23).

19. Кайсари ба Кармелын өмнөх Шароны Тал

Эртний далайн боомт Кайсарийн чанадад хойд зүг уруу харжээ. Тэрчлэн гэрэл зургийн дээд талд харагдаж буй нь Кармел уул юм.

Онцгой үйл явдлууд: Кармел ууланд Баалын хуурамч бошиглогчтой Елиа нүүр тулжээ (Хаад. дээд 18). Виа Марис (Далайн эргийн зам) нь Кайсарийн зүүн талаар тавигдсан эрт үеийн чухал зам бөгөөд Иоппад байхдаа ер бусын үзэгдлийн дараа Кайсарид Ромын цэргийн зуутын дарга Корнелд зааснаар Петр харийнханы дунд тохинууллаа эхэлжээ (Үйлс 10). Филип энд номлож мөн амьдарч байсан бөгөөд эш үзүүлэгч дөрвөн охинтой байв (Үйлс 8:40; 21:8–9). Энэ хотод Паул хоёр жил хоригджээ (Үйлс 23–26). Тэрээр Феликс, Фестус болон *Чи намайг бараг Христийнх болгохоор ятгачихлаа* хэмээн хэл-

сэн Херод Агрипп II нарт номложээ (Үйлс 26:28).

20. Иоппа

Иоппа хот далайн боомтын дээгүүр баруун хойд талд харагдаж байна.

Онцгой үйл явдлууд: Иона Иоппад ирж Таршиш уруу хөлөг онгоцоор явав (Иона 1:1–3). Иоппа нь ариун сүмүүдээ барихын тулд Ливаны хушин ойгоос гуалин авчрахад хэрэглэгдэж байсан, хожим нь Зеруббабел болсон Соломоны далайн боомт юм (Ном. үгс 2:16; Езра 3:7). Энд Петр Табита буюу Доркасыг босгон мөн амьдруулжээ (Үйлс 9:36–43). Харийнханы дунд тохиуулж эхлэх хэрэгтэйг түүнд илчилсэн цэвэр ба цэвэр бус амьтадын тухай үзэгдлийг тэрчлэн Петр харжээ (Үйлс 10). 1841 онд Ариун газрыг адислахаар Оорсон Хайд энд иржээ.

21. Иезреелийн хөндий

Табор уулнаас Иезреелийн хөндий тийш баруун зүгт харсан байна. Иезреелийн хөндийг ихэнхдээ нэг том хөндий мэт боддог хэдий ч, үнэндээ энэ нь Аккогийн тал, Иорданы хөндий болон Галилын тэнгис орчмын бүс нутгуудтай холбогдсон хэд хэдэн хөндий юм. Жишээ нь, Мегиддогийн хөндий бол энэ хөндийн баруун хэсэг юм. Иезреелийн хөндий нь баруун талдаа Газрын дундад тэнгис, зүүн талдаа Иорданы хөндий хоёрын дунд Ариун газрыг хөндлөн гатлах гол зам байв.

Онцгой үйл явдлууд: Египет, Месопотамийг холбосон хамгийн том зам энэ хөндийг дамжин өнгөрдөг бөгөөд олон дайн энд болжээ (Шүүгч. 1:22–27; 5:19; Хаад. дэд 23:29–30). Энэ нутгийн агуу бөгөөд сүүлчийн тулалдаан болох Аврагчийн Хоёр дахь ирэлтийн өмнөхөн тулалдах Хар Мегиддон буюу Мегиддон уулын нэрээр нэрлэгдэх Армагеддоны тулалдаан эхлэх болно (Езек. 38; Иоел 3:9–14; Зек. 14:2–5; Илч. 16:14–16).

22. Табор уул

Баруун хойшоо харжээ. Табор уулын бэлийг тойрон Иезреелийн хөндий, тэрчлэн Есдраелоны тал байдаг. Назар хот Табор уулын ар дахь толгодын дунд байдаг.

Онцгой үйл явдлууд: Дебора, Барак хоёр Хазорын хаан Иабини эсрэг Их Эзэний хүчээр нэгдэв (Шүүгч. 4:4–14). Табор уул нь Аврагчийн Хувиралтын уламжлалт газруудын нэг (Мат. 17:1–9); нөгөөдөх нь Хермон уул

юм (Судруудын удирдамж, “Хувиралт”-ыг үз).

23. Галилын тэнгис ба Ерөөлийн уул

Галилын тэнгисийн баруун хойд талын булан дээгүүр баруун урагш харсан, цэнгэг уст нуур. Тиберийн эргээс нилээд хол гэрэл зургийн тэртээх зүүн буланд байна. Үүний төвд байгаа толгод нь Ерөөлийн уул гэгддэг газар юм. Капернаум зурагт ороогүй боловч зүүн талд нь байгаа болно.

Онцгой үйл явдлууд: Аврагч мөнх бус байдлын тохиноуллынхаа ихэнхийг энэ бүс нутагт өнгөрөөжээ. Энд тэрээр Арванхоёр Төлөөлөгчөө дуудаж мөн томилон (Мат. 4:18–22; 10:1–4; Марк 1:16–20; 2:13–14; 3:7; 13–19; Лук 5:1–11), Уулан дээрх Номлолоо зааж (Мат. 5–7), мөн сургаалт зүйрлэлүүдээ заажээ (Мат. 13:1–52; Марк 4:1–34). Түүний үйлдсэн гайхамшгуудад: уяман өвчтэй хүнийг эдгээж (Мат. 8:1–4); шуурга намдаан (Мат. 8:23–27); залуу хөвгүүний дотроос олон чөтгөрийг зайлуулж, тэгснээр тэд гахайн дотор орж далай уруу унасан (Марк 5:1–15); Иайрын охиныг нас барагсдаас амилуулж (Мат. 9:18–19, 23–26; Марк 5:22–24, 35–43); 5000, 4000 эрэгтэйг хооллон (Мат. 14:14–21; 15:32–38); шавь нартаа тороо хаяхыг зарлигласнаар тэд олон загас барьж (Лук 5:1–6); олон хүмүүсийг эдгээсэн (Мат. 15:29–31; Марк 3:7–12); шавь нартаа заахаар Амилсныхаа дараа хүрч ирсэн (Марк 14:27–28; 16:7; Иохан 21:1–23) зэрэг нь багтана.

24. Капернаум

Галилын тэнгисийн хойд эрэг дээр оршдог Капернаум нь Галилд Есүсийн хийсэн тохиноуллын төв байв (Мат. 9:1–2; Марк 2:1–5). Загасны аж ахуй болон арилжааны чухал болоод ашигтай энэ төв харийнхан болон иудейчүүдийн аль алиных нь нутаг байв. Эхний зуун жилд хүн ам нь хэзээ ч 1000-аас илүү байгаагүй болов уу. Капернаум нь худалдааны зам хөндлөн гардаг үржил шимтэй газраар хүрээлэгдсэн газар байжээ. Ромын цэргүүд сайн зохион байгуулалттай нийгмийн байгууламжуудыг сайн бүтэцтэй олон нийтийн барилгуудын хамт бий болгосон халуун усны газар болон агуулах барьжээ. Энд олон гайхамшиг үйлдэгдсэн боловч, ихэнх тохиолдолд хүмүүс Аврагчийн тохиноуллыг эсэргүүцдэг байв. Иймээс Есүс энэ хотыг зүхсэн ажээ (Марк 11:20, 23–24). Ингэснээр Капернаум эзгүйрч, ямар ч оршин суугч энд үлдээгүй аж.

Онцгой үйл явдлууд: Капернаумыг Аврагчийн төрөлх хот гэдгээр нь мэддэг байв (Мат. 9:1–2; Марк 2:1–5). Тэрээр энэ газар олон гайхамшигийг үйлджээ. Жишээ нь, тэрээр олон хүмүүсийг (Марк 1:32–34) эдгээсний дотор зуутын даргын зарц (Лук 7:1–10), Петрийн хадам эх (Марк 1:21, 29–31), ортой нь дэвээр дээрээс доош буулгасан саа өвчтэй хүн (Марк 2:21–28, 32–34), хатингар гартай хүн (Мат. 12:9–13) зэрэг нь багтана. Энд Есүс тэрчлэн олон муу ёрын сүнснийг зайлуулжээ (Марк 1:21–28, 32–34), Иайрын охиныг нас барагсдаас амилуулж (Марк 5:22–24, 35–43), мөн Капернаумын синагогт амьдралын талхны номлолыг заажээ (Иохан 6:24–59). Галилын тэнгисээс загас барихыг, амаа нээхийг, татвараа төлөх мөнгө олохыг Аврагч Петрт зааварлажээ.

25. Иордан гол

Иордан гол нь Галилын тэнгисийн хойд талаас эхлэн үүнд цутгаад Сөнөсөн тэнгис уруу цааш үргэлжлэн урсдаг.

Онцгой үйл явдлууд: Лот Иорданы талыг өөртөө сонгон авчээ (Эхл. 13:10–11). Иошуа израилчуудыг амлагдсан нутаг уруу гатлуулахын тулд усыг хуваав (Иош. 3:13–17; 4:1–9, 20–24). Елиа, Елиша хоёр усыг хуваажээ (Хаад. дэд 2:5–8, 12–14). Нааман өвчнөө эдгээв (Хаад. дэд 5:1–15). Иохан Баптист Аврагч болон өөр олон хүмүүст баптисм хүртээжээ (Мат. 3:1–6, 13–16). (Судруудын удирдамж, “Иордан гол”-ыг үз.)

26. Цезарь Филип

Энэ горхи Хермон уулын бэлд байдаг. Энэ нь Иордан голын ундаргуудын нэг. Энэ газар нутгийг захирч байсан Херод Филип Цезарийн (түүний эзэн хаан) хүндэтгэлд болон өөртөө зориулж энд хот босгожээ; хотыг урьд нь Паниас хэмээн нэрлэдэг байсан бөгөөд өнөөдөр Баниас буюу Цезарь Филип хэмээн нэрлэдэг.

Онцгой үйл явдал: Цезарь Филипд Аврагч шавь нартайгаа уулзжээ. Энд Аврагч бол “Христ, амьд Бурханы Хүү” хэмээн Петр тунхаглажээ. Тэгээд тэнгэрийн хант улсын түлхүүрүүдийг Аврагч Петрт амласан байна (Мат. 16:13–20).

27. Назар

Энд харагдаж буй орчин үеийн хот Назар урд зүг уруу харжээ. Библийн үед Назар жижигхэн тосгон байжээ.

Онцгой үйл явдлууд: Аврагчийн эхийг Назарт байгааг Нифай үзэгдэлд харжээ (1 Ниф. 11:13–22). Аврагчийг тэр төрүүлэх болно хэмээн тэнгэр элч Габриел Мариад хэлжээ (Лук 1:26–35). Мариаг эхнэрээ болгон авч, түүний хүүхдийг Есүс хэмээн нэрлэж хэмээн Габриел Иосефт хэлжээ (Мат. 1:18–25). Есүс Назарт өссөн байна (Мат. 2:19–23; Лук 2:4–40; 4:16). Тэрээр номлож мөн синагогт Мессиа (Лук 4:16–21) гэдгээ зарласан боловч Назарын хүмүүс түүнийг эсэргүүцжээ (Мат. 13:54–58; Лук 4:22–30).

28. Дан

Израилчууд энэ нутгийг эзлэхээс өмнө эртний энэ хот Лешем (Иош. 19:47) буюу Лаиш (Шүүгч. 18:7, 14) хэмээн нэрлэгддэг байжээ. Цезарь Филип дэх шанднуудын хамт энэ нутгийн олон шанд Иордан голын эх ундарга болдог.

Онцгой үйл явдлууд: Абрахам Лотыг аварчээ (Эхл. 14:13–16). Даны удмынхан энэ газрыг эзэлж үүнийг Дан хэмээн нэрлэсэн байна (Иош. 19:47–48). Иеробоам алтан тугал хийсэн нь умардын 10 овгийн уналтад нэмэр болжээ (Хаад, дээд 12:26–33). Дан нь Израилын хамгийн хойд талын хот бөгөөд иймээс сударт Израилын газар нутгийг “Беершебагаас бүр Дан хүртэл” хэмээн хэлдэг байв (Шат. дэд 30:5; Беершеба бол хамгийн урд талын хот байв). (Судруудын удирдамж, “Дан”-ыг үз.)

29. Афин

Энэ гэрэл зураг нь Афин дахь Парфеноны балгасыг зүүлжээ. Афин нь эртний Грекийн нийслэл Атика буюу Шинэ Гэрээний үед Ромын муж байсан Ахей байв. Энэ нь Грекчүүдийн мөргөдөг охин тэнгэр Афиныг хүндэтгэн нэрлэсэн нэр юм. Шинэ Гэрээний үед Афин нь урьд өмнөх агуу байдал болон алдар сугаа алдсан боловч олон тооны бурхад, охин тэнгэрүүдийн хөшөө, түүний дотор “үл мэдэгдэх бурхны” баримлуудыг хэвээр хадгалсаар иржээ (Үйлс 17:23).

Онцгой үйл явдлууд: Төлөөлөгч Паул хотод ирж Парфеноны ойролцоох Марсын Уулан дээр номложээ (Үйлс 17:15–34). Афинаас Грекийн бусад хэсгүүд уруу номлогчдыг илгээж байв (1 Тес. 3:1–2).

30. Коринт

Ромын муж Ахейн гол хот. Энэ нь Пелопоннесыг Грекийн эх газартай холбосон зүүн болон баруун талуудын далайн боомтыг эзэмшдэг суваг дээр оршдог байв. Энэ нь баян бөгөөд их хөлийн далайн боомт хот байлаа.

Онцгой үйл явдлууд: Паул Коринтод жил зургаан сар амьдарч мөн Сүмийг үндэслэн байгуулжээ (Үйлс 18:1–18). Паул Коринт хавийн Сүмийн гишүүдэд хэд хэдэн захидал бичсэний хоёр нь одоо Шинэ Гэрээнд байдаг (1, 2-р Коринт).

31. Ефес

Төлөөлөгч Паулын номлож асан Ефес дэх грек театрын балгас. Шинэ Гэрээний үед Ефес ромчуудын мөргөдөг охин тэнгэр Дианад зориулан босгосон гайхамшигт ариун сүмээрээ дэлхийд алдартай байжээ. Одоо байгаа энэ балгас дотор Ефес нь Ромын муж Азийн нийслэл бөгөөд худалдааны том төв байв. Хотын мөнгөний дархчууд Дианагийн дүрсийг гоёмсоор хийж худалдах зах зээлийг сайн хөгжүүлсэн ажээ.

Онцгой үйл явдлууд: Төлөөлөгч Паул Ефест хоёр дахь номлолынхоо төгсгөлд очжээ (Үйлс 18:18–19). Гурав дахь аялалдаа тэрээр энэ хотод хоёр жил амьдарчээ. Хуурамч охин тэнгэр Дианаг шүтэхийн эсрэг номлосны улмаас арилжаагаа алдсан мөнгөний дархчууд Паулыг эсэргүүцсэнээр тэрээр эндээс явахаас аргагүйд хүрсэн аж (Үйлс 19:1, 10, 23–41; 20:1). Ефесийн театр нь грекчүүдийн барьсан хамгийн том барилга бөгөөд Паулын нөхөд дээрэмчидтэй тулгарсан газар юм (Үйлс 19:29–31). Паул Ромд хоригдол байхдаа Ефес дэх Сүмийн гишүүдэд захидал бичжээ. Илчлэлтийн номонд гардаг Ази дахь Сүмийн долоон салбарын нэг нь Ефест байжээ (Илч. 1:10–11; 2:1).

32. Патм арал

Иоханы цөлөгдсөн Эгейн тэнгис дэх арал (Илч. 1:9). Ам дамжсан яриагаар бол, тэрээр тэнд гантигийн уурхайд ажиллаж байжээ.

Онцгой үйл явдал: Иохан Апокалипс (Илчлэлтийн ном) хэмээн мэдэх агуу үзэгдлийг Иохан үзжээ. Уг үзэгдлийг Ази дахь долоон сүм уруу илгээ хэмээн Их Эзэн түүнд хэлсэн ажээ (Илч. 1:11).

Дараах газрын зургууд нь судруудыг илүү сайн ойлгоход тань танд тусална. Судруудад бичигдсэн нутгийн газарзүйг сайн мэдсэ-

нээрээ та судруудын үйл явдлыг илүү сайн ойлгож чадна.

- | | |
|--|---|
| <ol style="list-style-type: none"> 1. АРИУН НУТГИЙН ГАЗАР ЗҮЙН ЗУРАГ 2. ИЗРАЙЛЧУУД ЕГИПЕТЭЭС ГАРЧ, КАНААНД ИРСЭН НЬ 3. 12 ОВГИЙН ХУВААГДАЛТ 4. ДАВИД БОЛОН СОЛОМОНЫ ЭЗЭНТ ГҮРЭН 5. АССИРИЙН ЭЗЭНТ ГҮРЭН 6. ШИНЭ ВАВИЛОНЫ ЭЗЭНТ ГҮРЭН (Небухаднезар) БА ЕГИПЕТИЙН ХААНТ УЛС 7. ПЕРСИЙН ЭЗЭНТ ГҮРЭН | <ol style="list-style-type: none"> 8. РОМЫН ЭЗЭНТ ГҮРЭН 9. ХУУЧИН ГЭРЭЭНИЙ ҮЕИЙН ДЭЛХИЙ 10. ХУУЧИН ГЭРЭЭНИЙ ҮЕИЙН КАНААН 11. ШИНЭ ГЭРЭЭНИЙ ҮЕИЙН АРИУН НУТАГ 12. ЕСҮСИЙН ҮЕИЙН ИЕРУСАЛИМ 13. ТӨЛӨӨЛӨГЧ ПАУЛЫН НОМЛОЛЫН АЯЛЛУУД 14. БИБЛИЙН ҮЕИЙН АРИУН НУТГИЙН ӨНДӨРЛӨГҮҮД |
|--|---|

Газруудын нэрний цагаан толгойн дарааллаарх жагсаалт нь тодорхой нэг газрыг газрын зураг дээр олоход танд тусална. Тайлбар бүрд газрын зургийн дугаарын ард үсэг болон тоог хослуулсан солбилцлын заалтыг багтаасан болно. Жишээ нь: эхний газрын зураг дээр Рабба (Амман)-ыг бичихдээ 1:Д5 гэжээ; энэ нь, Д5 гэсэн хавтгай дахь газрын зураг 1 гэсэн үг юм. Та газрын зураг бүр дээр газрын зургийн дээд талыг хажуу талтайгаа солбилцох солбилцлыг мэдсэнээр тодорхой нэг хавтгайг олж чадна. Газруудын өөр нэрсийг хаалтанд жагсаасан болно; жишээ нь, Рабба (Амман). Нэрний ард байгаа асуултын тэмдэг нь газрын зураг дээр үзүүлж буй газар тодорхой биш буюу байж болзошгүйг заадаг.

Дараах нь газрын зураг дээр ашигласан янз бүрийн бэлэгдэл болон бичиглэлийг ойлгох түлхүүр юм. Үүнээс гадна, газрын зураг зөвхөн тухайн газрын зурагт хамааралтай нэмэлт бэлэгдлүүдийн тайлбарыг агуулсан байж болно.

- Улаан цэг нь хот буюу тосгоныг заадаг.
- Заримдаа тухайн цэгээс хот буюу газрын нэр уруу шугамаар заасан байдаг.

▲ Жижигхэн хар гурвалжин нь уулсыг заадаг.

СӨНӨСӨН ТЭНГИС Энэ бичиглэл нь далай, тэнгис, нуур, гол уул, тал, хөндий, цөл болон арал гэх мэт газарзүйн байрлалуудад хэрэглэгддэг.


Иерусалим Энэ бичиглэл нь бүх хот болон тосгодоод (Иерусалим хотын газрын зураг дээрх хэсэгчилсэн байрлалуудад) хэрэглэгддэг.

МОАБ Энэ бичиглэл нь муж, хүмүүс, овог гэх мэт жижиг улс төрийн нэгжүүдэд хэрэглэгддэг.

И У Д Е Й Энэ бичиглэл нь үндэстэн, улс болон тив зэрэг улс төрийн томоохон нэгжүүдэд хэрэглэгддэг.

ЗАГВАР ГАЗРЫН ЗУРАГ

ХӨТӨЧ ГАЗРЫН ЗУРАГ



ГАЗРЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ


<p>Абана гол, 1:Г1 Абилен, муж, 11:Г1 Адри, тэнгис (Адриатын), 8:Б2 Аенон, 11:В4 Ази, Ромын муж, 8:В2, 13:Е2 Азот, 11:А6 Ай, 2:Г1, 10:Б5, 11:Б6 Айжалон, 1:Б5, 10:Б5, 11:Б5 Акабагийн булан, 2:Г4 Акад (Аккад), муж, 9:Ё2 Аккад (Акад), муж, 9:Ё2 Акко (Ако, Птолемей), 1:Б3, 3:А3, 4:В3, 10:Б2, 11:Б3 Александр, 8:В3, 13:Е4 Амалек, муж, 4:В6 Амман (Рабаба), 1:Г5, 10:Г5, 14:Г2 Аммон, муж, 1:Г6, 3:Б5, 4:Г4, 10:Г6 Антиох, Писидиа дахь, 13:Е2 Антиох, Сири дэх, 8:В3, 13:Ж2 Апиусын Дүрс, 13:Б1 Араб, 5:В3, 8:Г4 Араб (Рифтийн Хөндий), 1:Б8, 2:Г2, 4:В7, 10:Б8 Арабын цөл, 9:Е3 Арад, 2:Г1, 3:А5, 4:В5 Арал тэнгис, 5:Г1, 6:Г1, 7:В2 Арам-Дамаск, муж, 4:Г2 Арарат Уул, 9:Е1 Аргоб муж, 4:Г3 Аримат, 11:Б5 Арнон, 2:Д1 Арнон гол, 1:Б7, 2:Г1, 3:Б5, 4:Г5, 10:Б7, 11:Б7 Аскалон (Ашкелон), 11:А6 Ассири, 9:Е2 Ассирийн Эзэнт гүрэн, 5:В3 Ашшур, 5:В3, 9:Е2 Афин, 6:А2, 7:А2, 8:Б2, 13:Г2</p>	<p>Ахей, Ромын муж, 8:В2, 13:Г2 Ашдод, (Азот), 1:А6, 3:А5, 4:Б5, 10:А6 Ашшерын овог, 3:А3 Ашкелон (Аскалон), 1:А6, 3:А5, 4:Б5, 10:А6, 11:А6 Бабел (Шинар), 9:Ё3 Башан, муж, 1:В3, 10:В2 Безет, 12:Б2 Бениамины овог, 3:А5 Берой, 13:Г1 Бершиб, 1:Б7, 2:В1, 3:А5, 4:В6, 9:Г4, 10:Б7, 11:Б8 Бесор гол, 1:А7, 10:А7, 11:А8 Бетан, 11:В6 Бетан, 11:Б6 Бетан хүрэх зам, 12:Г5 Бетел (Луз), 3:А5, 4:Б5, 10:Б5, 11:Б6 Бетлехем, 1:Б6, 3:А5, 4:Б5, 10:Б6, 11:Б6 Бетлехем хүрэх зам, 12:А7 Бетсайд, 11:В3 Бетфаг, 11:Б6 Бет-шан, 3:Б4, 4:Г4, 10:В4 Битин, муж, 13:Е1 Бозра, 3:Б6, 4:Г6 Британи, муж, 8:А1 Вавилон, 5:В3, 6:В3, 7:Б3, 9:Е3 Вавилон, муж, 9:Е3 Гадар, 11:В4 Гадын овог, 3:Б4 Галат, муж, 13:Ё1 Газрын дундад (Их, Дээд) тэнгис, 1:А5, 2:Б1, 3:А4, 4:В4, 5:А3, 6:А3, 7:А3, 8:Б3, 9:Б3, 10:А5, 11:А6, 13:Г3, 14:А2, 14:А6 Газрын дундад тэнгисийн түвшин, 14:А2, 14:А6 Галил, муж, 11:Б2 Галилын дээд муж, 1:Б2 Галилын доод муж, 1:В3</p>	<p>Галилын (Чинерет) тэнгис, 1:В3, 3:Б3, 4:Г3, 9:Г3, 10:В3, 11:В3, 14:Б7 Газ, 1:А6, 2:В1, 3:А5, 4:Б5, 10:А7, 13:Ж4 Гат, 3:А5, 4:Б5, 10:А6 Гат-хепер, 10:Б3 Гаул, муж, 8А1 Гезер, 4:Б5 Герар, 10:А7 Герар гол, 1:А7, 10:А7, 11:А7 Геризим уул, 1:Б5, 3:А4, 4:В4, 10:Б5, 14:Б6 Германи муж, 8:Б1 Гешур муж, 4:Г3 Гибеон, 10:Б5 Гиби, 4:В5 Гилбао уул, 1:В4, 3:Б4, 10:В4, 11:В4, 14:В6 Гилгал, 1:Б5, 2:Г1, 4:Г5 Гилеад муж, 1:В4, 10:В4 Гоморра болон Содомын бүс нутаг, 10:Б8 Гошен муж, 2:А2, 9:В4 Грек, 7:А2 Гурван дэн буудал, 13:Б1 Давст нуур, (Сөнөсөн тэнгис), 1:В6, 2:Г1, 3:Б5, 4:Г5, 9:Г4 Дамаск, 1:Г1, 3:Б2, 4:Г2, 9:Г3, 10:Г1, 11:Г1, 13:Ж3 Дан (Лейш), 1:В2, 3:Б3, 4:Г3, 10:В2 Даны овог, 3:Б3, 3:А5 Дасиа, муж, 8:Б2 Декапол, муж, 11:В4 Дерб, 13:Ё2 Дибон, 2:Г1 Дор, 3:А4, 4:В4 Дорнод (Доод) тэнгис, 5:В4, 6:В4 Дорнод хээр тал, 2:Г3 Дотан, 10:Б4 Дофка, 2:В 4 Дундад тэнгис (Дорнод тэнгис, Персийн булан), 5:В4, 6:В4, 7:Б4, 8:Г3, 9:Ж3</p>
---	---	--

<p>Дурагийн Тал, 9:Е2 Дээд (Их, Газрын дундад) тэнгис, 7:А3, 9:Б3</p> <p>Ебал уул, 1:Б4, 3:А4, 4:В4, 10:Б4, 11:Б5, 14:Б6</p> <p>Египет дэх Суккоч, 2:Б2 Египет, муж, 2:А3, 5:Б4, 7:А4, 8:В4, 9:В4, 13:Е4</p> <p>Египетийн гол, 2:В2 Египетийн хаант улс, 6:А3</p> <p>Едом, муж, 1:В8, 2:Г2, 3:Б6, 4:Г7, 10:В8</p> <p>Езион-гебер, 2:Г3, 3:А8, 4:В8, 9:Г4</p> <p>Екрон, 1:Б6, 10:А6 Ела, 1:А6, 10:Б6, 11:Б6 Елам, муж, 5:В3, 6:В3, 7:В3, 9:Ж3</p> <p>Елим, 2:В3 Еммау, 11:Б6 Еммау хүрэх зам, 12:А4 Ен-геди, 4:Г5, 10:В7 Ендор, 10:В3 Ен-рогел булаг, 12:В7 Есдраелоны хөндий, 1:Б3, 10:Б3</p> <p>Ефес, 8:С2, 13:Д2 Ефраимын овог, 3:А4 Ефрат мөрөн, 5:Б3, 6:В3, 8:Г3, 9:Д2</p> <p>Зебулуны овог, 3:А3 Зерд гол, 1:В8, 2:Г2, 3:Б6, 4:Г6, 10:В8, 11:В8 Зиклаг, 4:В5 Зиний аглаг буйд, 2:В2</p> <p>Иаббок мөрөн, 1:Б5, 3:Б4, 4:Б4, 10:В5, 11:В5 Иабеш-гилеад, 3:Б4 Идумеа муж, 1:Б7, 10:Б7, 11:Б7 Иезреел, 4:Г4, 10:Б4 Иезреелийн хөндий (Есдраел), 1:Б3, 10:Б3 Иерихо, 1:Б5, 2:Г1, 3:Б5, 4:Г5, 10:Б5, 11:Б6, 14:А7, 14:В3</p>	<p>Иерихо хүрэх зам, 12:Г5 Иерусалим дахь, Антони цайз, 12:В3 Иерусалим дахь Ариун сүмийн довжоо, 12:Г5 Иерусалим дахь Бетзадагийн цөөрөм, 12:В3 Иерусалим дахь Гетсеманийн Цэцэрлэг, 12:Г4 Иерусалим дахь Гихоны шанд, 12:Г6 Иерусалим дахь Голгота, 12:Б3 Иерусалим дахь Дээд өрөө, 12:Б6 Иерусалим дахь Израилын Усан сан, 12:В4 Иерусалим дахь Каиафын гэр, 12:Б6 Иерусалим дахь Кидроны хөндий, 12:Г6 Иерусалим дахь Могойн тохой, 12:А6 Иерусалим дахь Пинакле Ариун сүм, 12:Г5 Иерусалим дахь Силоам тохой, 12:В7 Иерусалим дахь Соломоны жигүүрийн асар, 12:Г4 Иерусалим дахь Сусаны хаалга, 12:Г4 Иерусалим дахь Хааны жигүүрийн асар, 12:В5 Иерусалим дахь Хасмоны ордон, 12:В5 Иерусалим дахь Хезекиагийн суваг, 12:В6 Иерусалим дахь Херодын ордон, 12:Б5 Иерусалим дахь Хинномын хөндий, 12:Б7 Иерусалим дахь Хонины хаалга, 12:В4</p>	<p>Иерусалим (Салем), 1:Б6, 2:Г1, 3:А5, 4:В5, 5:Б3, 6:Б3, 7:А3, 8:В3, 9:Г3, 10:Б6, 11:Б6, 13:Ж3, 14:Б2, 14:Б6 Иерусалим Дээд хот, 12:Б6 Иерусалим Доод хот, 12:В6 Иерусалим дахь Цамхагийн тохой, 12:Б5 Иерусалимын ариун сүм, 12:В4 Иерусалимын Булшны цэцэрлэг, 12:Б3 Иерусалимын Загасан хаалга, 12:Б3 Иерусалимын Усны хаалга, 12:В7 Израил дахь Суккоч, 3:Б4, 4:Г4 Израил, муж, 4:В4 Икони, 13:Ё2 Инд мөрөн, 7:Г4 Иоппа, 1:А5, 3:А4, 4:В4, 10:А5, 11:А5, 13:Ж3 Иоппа хүрэх зам, 12:А4 Иордан Гол, 1:Б5, 2:Г1, 3:Б4, 4:Г4, 10:В5, 11:Б5 Иорданы чанд дахь Дорнодын өндөрлөг газар, 14:Г2 Иссахарын овог, 3:Б4 Итали, Ромын муж, 8:Б2, 13:А1 Иудей, муж, 5:Б3, 10:Б7 Иудей, муж, 1:Б6, 11:Б7 Иудей, овог, 3:А5 Иудейн уулархаг нутаг, 14:Б2 Иудейн хээр тал, 1:Б7, 11:Б7 Ифамын хээр тал, 2:Б3 Их (Газрын дундад тэнгисийн дээд хэсэг) тэнгис, 1:А4, 2:Б1, 3:А4, 4:В4, 5:А3, 6:А3, 7:А3, 9:Б3, 10:А5, 11:А6, 13:Г3, 14:А2, 14:А6</p>
---	---	---

ГАЗРЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ

<p>Кадеш-барне, 2:В2, 3:А6, 4:В6</p> <p>Кайсари, 11:Б4, 13:Ж3</p> <p>Кан, 11:В3</p> <p>Канаан, муж, 2:В1, 9:Г3</p> <p>Капернаум, 11:В3</p> <p>Каппадок, муж, 13:Ж2</p> <p>Кармел Уул, 1:Б3, 3:А3, 4:В3, 10:Б3, 11:Б3</p> <p>Картейж, 8:Б3</p> <p>Кархемиш, 5:Б2, 6:Б2, 9:Г2</p> <p>Каспийн тэнгис, 5:В1, 6:В1, 7:Б2, 8:Г2, 9:Ё1</p> <p>Каукас уулс, 5:В1, 8:Г2, 9:Е1</p> <p>Кафтор (Крет), арал, 9:А3</p> <p>Кипр (Киттим), арал, 8:В3, 9:В3, 13:Е3</p> <p>Кир-харесец, 10:В7</p> <p>Киттим (киор) арал, 9:В3</p> <p>Кишон гол, 1:Б3, 10:Б3, 11:Б3</p> <p>Книд, арал, 13:Д2</p> <p>Коринт, 13:Г2</p> <p>Крет (Каптор), арал, 8:В3, 9:А3, 13:Г3</p> <p>Курен, 13:Г3</p> <p>Лаодик, 13:Е2</p> <p>Лахиш, 1:А6, 3:А5, 4:В5, 10:А6</p> <p>Ливаны уулс, 1:В1, 10:В1, 11:В1</p> <p>Ливи, 8:Б3, 13:В4</p> <p>Ливийн цөл, 9:Б4</p> <p>Литани гол, 1:В1, 10:В1, 11:В2</p> <p>Луд, муж, 13:Д2</p> <p>Луз (Ветел), 10:Б5</p> <p>Лук, муж, 13:Е2</p> <p>Лустр, 13:Ё2</p> <p>Лэйш (Дан), 10:В2</p> <p>Магадан, 11:В3</p> <p>Македони, муж, 7:А2, 8:В2, 13:Г1</p> <p>Маккаер, 11:В7</p> <p>Мальт, арал, 13:Б3</p> <p>Манасе овог, 3:А4, 3:Б3</p>	<p>Мара, 2:Б3</p> <p>Маре Интер (Их, Газрын дундад, Дээд тэнгис), 8:Б3</p> <p>Маханаим, 10:В4</p> <p>Мегиддо, 1:Б3, 3:А4, 4:В4, 6:Б3, 9:Г3, 10:Б3</p> <p>Медеб, 4:Г5</p> <p>Медийн Эзэнт гүрэн, 6:Г3</p> <p>Мельт (Мальт) арал, 13:Б3</p> <p>Мемфис (Ноф), 2:А3, 5:Б3, 6:Б3, 7:А3, 8:В3</p> <p>Меромын ус (Хюле Нуур), 10:В2</p> <p>Месопотами, 8:Г3, 9:Д2</p> <p>Мициан, муж, 2:Г4, 9:Г4</p> <p>Милет, 13:Е2</p> <p>Мира, 13:Е2</p> <p>Мисен, 5:А2</p> <p>Мисиа, муж, 13:Д2</p> <p>Моаб муж, 1:В7, 2:Г1, 3:Б6, 4:Г6, 10:В7</p> <p>Моабын хээр тал, 1:В6, 11:В6</p> <p>Мориа уул, 14:Б6</p> <p>Морийн нуруу, 1:В3, 10:Б3</p> <p>Набата, муж, 11:В8</p> <p>Назар, 1:Б3, 11:Б3</p> <p>Наин, 11:В4</p> <p>Нафтали овог, 3:Б3</p> <p>Небо уул, 1:В6, 2:Г1, 3:Б5, 4:Г5, 10:В6, 11:В6</p> <p>Негев муж, 1:А8, 10:А8</p> <p>Нилийн адаг, 2:А2, 9:В4</p> <p>Нил мөрөн, 2:А3, 5:Б4, 7:А4, 8:В4, 9:В4</p> <p>Ниневе, 5:В2, 9:Е2</p> <p>Ноф (Мемпис), 2:А3</p> <p>Нүглийн хөндий, 2:Б4</p> <p>Он (Хелиопол), 2:А3, 9:В4</p> <p>Падан-арам (Харан), 9:Д2</p> <p>Памфили муж, 13:Е2</p> <p>Параны хээр тал, 2:В3</p> <p>Парфын эзэнт гүрэн, 8:Г3</p> <p>Патм арал, 13:Д2</p> <p>Паф, 13:Ё3</p>	<p>Пенуел, 10:В4</p> <p>Пера, 11:В5</p> <p>Перг, 13:Е2</p> <p>Пергам, 13:Д2</p> <p>Перс, 5:Г4, 6:Г4</p> <p>Персийн булан, (Доод тэнгис), 9:Ж3</p> <p>Писид муж, 13:Е2</p> <p>Пифом, 2:Б2</p> <p>Пи-хахирот, 2:Б3</p> <p>Понт, муж, 13:Ё1</p> <p>Птолим (Акко, Акчо), 1:Б3, 11:Б3, 13:Ж3</p> <p>Путеоли, 13:Б1</p> <p>Рабба (Амман), 1:Г5, 3:Б5, 10:Г5</p> <p>Рамесес (Танис), 2:Б2</p> <p>Рамот-гилеад, 3:Б4, 4:Г4</p> <p>Региум, 13:Б2</p> <p>Реубены овог, 3:Б5</p> <p>Рефидем, 2:В4</p> <p>Роде арал, 9:Б3, 13:Д3</p> <p>Ром, 8:Б2, 13:А1</p> <p>Салам, 13:Е3</p> <p>Салем (Иерусалим), 9:Г3</p> <p>Салим, 11:В4</p> <p>Самари, 1:Б4, 5:Б3, 10:Б4, 11:Б5, 13:Ж3</p> <p>Самари, муж, 1:Б4, 10:Б4, 11:Б4</p> <p>Самари хүрэх зам, 12:Б1</p> <p>Самотр арал, 13:Д1</p> <p>Сарепта, 11:Б1</p> <p>Сармат муж, 8:Б1</p> <p>Сидон, 1:В1, 3:А2, 4:Г2, 9:Г3, 10:В1, 11:В1, 13:Ж3</p> <p>Силиси, муж, 13:Ё2</p> <p>Симеоны овог, 3:А6</p> <p>Синайн хээр тал, 2:Б4</p> <p>Синайн хойг, 2:Б3</p> <p>Синай уул (Хороб), 2:В4, 9:Г4</p> <p>Сионы уул, 14:Б6</p> <p>Сирак, 13:Б2</p> <p>Сири муж, 6:Б3, 8:В3, 9:Г3, 11:Б2, 13:Ж3</p> <p>Смирна, 13:Д2</p>
---	---	--

<p>Содом болон Гоморрагийн бүс нутаг, 10:Б8 Сорек гол, 1:Б6, 10:Б6, 11:Б6 Сөнөсөн тэнгис, (Давст нуур) 1:Б6, 2:Г1, 3:Б5, 4:Г5, 9:Г4, 10:Б6, 11:Б7, 14:А7, 14:В3 Сөнөсөн тэнгис хүрэх зам, 12:В8 Сөнөсөн тэнгисийн ёроол, 14:В3 Сөнөсөн тэнгисийн түвшин, 14:А7, 14:В3 Спарта, 6:А2, 7:А2 Суса (Шушан), 6:В3, 7:Б3, 9:Ё3 Сухар, 11:Б5 Суэцын булан, 2:Б3 Табор Уул, 1:В3, 3:Б4, 4:Г4, 10:В3, 11:В3, 14:В6 Тан (Рамесе), 2:Б2 Тарс, 13:Ё2 Теб, 5:Б4, 6:Б4, 7:А4, 8:В4 Текоа, 10:Б6 Тесалоник, 8:В2, 13:Г1 Тибер, 11:В3 Тигр мөрөн, 5:В2, 6:В2, 8:Г3, 9:Ё3 Тир, 1:Б2, 3:А3, 4:В3, 9:Г3, 10:Б1, 11:Б2, 13:Ж3 Трой, 6:А2, 7:А2, 13:Д2</p>	<p>Трой, 9:Б2 Улаан тэнгис, 2:Г4, 5:Б4, 6:Б4, 7:Б4, 8:В4, 9:Г4 Ур, 5:В3, 9:Д2, 9:Ж3 Урарт, муж, 9:Д1 Үзэсгэлэнт боомт, 13:Д3 Үзэсгэлэнт хаалга, 12:В4 Фарпар гол, 1:Г1, 10:Г1, 11:Г2 Филадельфи, 11:Г6 Филиппи, 13:Г1 Филистийн муж, 4:В5 Филистийн хээр тал, 1:А6, 10:А6 Филистийн хүмүүс, 2:В2 Фоеник, муж, 1:В1, 4:Г2, 9:Г3, 10:Б1, 11:Б2, 13:Ж3 Фриж, муж, 13:Е2 Хазор, 3:Б3, 4:Г3, 10:В2 Хар тэнгис, 5:Б1, 6:Б1, 7:А2, 8:В2, 9:Б1, 13:Е1 Харан (Падан-арам), 9:Д2 Хеброн, 1:Б6, 2:Г1, 3:А5, 4:В5, 10:Б7, 11:Б7 Хеброн хүрэх зам, 12:А7 Хелиопол (Он), 2:А3 Хермон уул, 1:В1, 3:Б2, 4:Г2, 10:В1, 11:Г1, 14:Г5 Хешбон, 4:Г5 Хиви хүмүүс, 3:Б2 Хитчүүд, хүмүүс 9:Г2</p>	<p>Хиспани, муж, 8:А2 Хор Уул, 2:Г2 Хороб (Синай Уул), 2:В4, 9:Г4 Хори хүмүүс, 9:Д2 Хорма, 2:Г1, 4:В6 Хээр талын буудал, 2:В4 Хюле нуур (Меромын ус), 10:Б2, 14:В6 Хюлен хөндий, 1:В2, 11:В2 Цейзарь Филип, 11:В2 Чидуны уул, 1:Б6, 10:Б6, 11:Б6, 12:Г4, 14:Б6 Чинеретийн тэнгис, 1:В3, 3:Б3, 4:Г3, 9:Г3, 10:В3, 11:В3 Чиос арал, 13:Д2 Чоразин, 11:В3 Шароны Тал, 1:Б4, 10:Б4, 11:Б5 Шекем, 3:А4, 4:В4, 10:Б4 Шефела, 1:Б6, 10:Б6, 14:Б2 Шило, 3:А4, 4:Г4, 10:Б5 Шинар (Бабел), 9:Ё3 Шинэ Вавилоны эзэнт гүрэн, 6:В3 Шурын хээр тал, 2:Б2 Шушан (Суса), 6:В3, 7:Б3, 9:Ё3 Ярмук гол, 1:С3, 10:В3, 11:В3</p>
---	--	---



БИБЛИД ХАМААРАХ ГАЗРЫН ЗУРГУУД

Дараах газрын зургуудыг судруудыг судлахад тусламж болгон мөн Сүмийн заавруудын цуврал хичээлүүдэд нэмэлт хөтөлбөр болгон оруулсан болно.

Дээрх газрын зургийн товчлол нь дагалдах дугаарласан газрын зураг бүрд байгаа болно. Эдгээр газрын зургууд нь том газар нутаг болон маш нарийвчлалтай газарзүйн хэсгүүдийг ч мөн адил хамарсан болно.

ГАЗРЫН ЗУРАГ 1 АРИУН НУТГИЙН БОДИТ ГАЗРЫН ЗУРАГ

ГАЗРЫН ЗУРАГ 2 ИЗРАИЛЧУУД ЕГИПЕТЭЭС ГАРЧ, КАНААНД ИРСЭН НЬ

ГАЗРЫН ЗУРАГ 3 12 ӨВГИЙН ХУВААГДАЛТ

ГАЗРЫН ЗУРАГ 4 ДАВИД БОЛОН СОЛОМОНЫ ЭЗЭНТ ГҮРЭН

ГАЗРЫН ЗУРАГ 5 АССИРИЙН ЭЗЭНТ ГҮРЭН

ГАЗРЫН ЗУРАГ 6 ШИНЭ ВАВИЛОНЫ ЭЗЭНТ ГҮРЭН (Небухаднезар) БА ЕГИПЕТИЙН ХААНТ УЛС

ГАЗРЫН ЗУРАГ 7 ПЕРСИЙН ЭЗЭНТ ГҮРЭН

ГАЗРЫН ЗУРАГ 8 РОМЫН ЭЗЭНТ ГҮРЭН

ГАЗРЫН ЗУРАГ 9 ХУУЧИН ГЭРЭЭНИЙ ҮЕИЙН ДЭЛХИЙ

ГАЗРЫН ЗУРАГ 10 ХУУЧИН ГЭРЭЭНИЙ ҮЕИЙН КАНААН


ГАЗРЫН ЗУРАГ 11 ШИНЭ ГЭРЭЭНИЙ ҮЕИЙН АРИУН НУТАГ

ГАЗРЫН ЗУРАГ 12 ЕСҮСИЙН ҮЕИЙН ИЕРУСАЛИМ


ГАЗРЫН ЗУРАГ 13 ТӨЛӨӨЛӨГЧ ПАУЛЫН НОМЛОЛЫН АЯЛЛУУД


ГАЗРЫН ЗУРАГ 14 БИБЛИЙН ҮЕИЙН АРИУН НУТГИЙН ӨНДӨРЛӨГҮҮД






- 1. Рамесес** Израил Египетээс явав (Ег. 12; Тоол. 33:5).
- 2. Суккот** Еврейчүүдийг анхныхаа хоноглосон газраас нүүхэд, Их Эзэн өдөр нь үүлэн баганад, шөно нь галан багананд тэдэнтэй хамт байв (Ег. 13:20–22).
- Пи-хакхирот** Израилчууд Улаан тэнгисийг үүгээр гаталжээ (Ег. 14; Тоол. 33:8).
- Мара** Их Эзэн Марагийн усыг цэвэршүүлжээ (Ег. 23–26).
- Елим** Израилчууд 12 булгийн дэргэд буудаллав (Ег. 15:27).
- Нүглийн хөндий** Израилчуудыг хооллохын тулд Их Эзэн манна болон бөднө шувууг илгээжээ (Ег. 16).
- Рефидим** Израилчууд Амалектай байлдав (Ег. 17:8–16).
- Синай уул (Хероб уул буюу Иебел Муса)** Их Эзэн Арван Зарлигийг илчилжээ (Ег. 19–20).
- Синайн цөл** Израилчууд асар босгожээ (Ег. 25–30).
- Цөлийн буудал** Мосе хүмүүсийг удирдахаар далан ахлагчийг дуудав (Тоол. 11:16–17).
- Езион-гебер** Израилчууд Есав болон Аммоны нутгаар амар амгалан дайрч өнгөрөв (Дэд хууль 2).
- 2. Кадеш-барне** Мосе амлагдсан нутаг уруу туршуулуудыг илгээв; Израилыг эсэргүүцэж нутаг уруу орж чадсангүй; Кадеш олон жил Израилын буудалласан гол газар байжээ (Тоол. 13:1–3, 17–33; 14; 32:8; Дэд хууль 2:14).
- 3. Дорнод цөл** Едом болон Моабтай зөрчилдөхөөс Израил зайлсхийв (Тоол. 20:14–21; 22–24).
- 4. Арнон гол** Израилчууд тэдний эсрэг байлдсан аморичуудыг устгажээ (Дэд хууль 2:24–37).
- 5. Небо уул** Мосе амлагдсан нутгийг харав (Дэд хууль 34:1–4). Мосе сүүлчийн гурван номлолоо номлосон ажээ (Дэд хууль 1–32).
- 6. Моабын тал** Уг нутгийг хуваан, оршин суугчдыг нь хөөн зайлуул хэмээн Их Эзэн Израилд хэлжээ (Тоол. 33:50–56).
- 7. Иордан гол** Израил Иордан голыг хуурай газраар гаталжээ. Гилгалын ойролцоо Иордан голоос авчирсан чулууныг Иорданы ус хуваагдсаны бэлэгдэл хөшөө болгон тавьсан ажээ (Иош. 3–5:1).
- 8. Иерихо** Израилын хүүхдүүд хотыг булаан эзэлж, устгажээ (Иош. 6).






ШИНЭ ВАВИЛОНЫ ЭЗЭНТ ГҮРЭН (Небухаднезар) БА ЕГИПЕТИЙН ХААНТ УЛС



ПЕРСИЙН ЭЗЭНТ ГҮРЭН


ГАЗРЫН ЗУРАГ 7



РОМЫН ЭЗЭНТ ГҮРЭН

ГАЗРЫН ЗУРАГ 8






1. **Арагат** уул Ам дамжсан яриагаар бoл, Ноагийн хөвчөг авдар газардсан газар (Эхл. 8:4). Яг тодорхой газар нь мэдэгдээгүй байна.
2. **Ур** Амьд хүнийг зохиослолын хохирогч болгох гэж байсан Абрахамын анхны нутаг, Иеховагийн тэнгэр элчийг харжээ, мөн Урим ба Тумимыг хүлээн авчээ (Эхл. 11:28-12:1; Абр. 1, 3:1). (Эрчлэн Месопотамийн хойд тал нь Урын нутаг байж болохгүйг анхаар).
3. **Вавилон, Бабел (Шинар)** Эхлээд Хамын хүү Кашл, мөн Нимрод нар амьдарч байжээ. Бабелын цамхагийн үед Шинарын галд иардчуудын улмынхны амьдарч байсан газар. Хожим нь Вавилон мужийн нийслэл мөн Иерусалимын устгалын дараа олон иудей олзлогдсыг энэ хотод авчирсан Небухаднезар эзрэг Вавилоны хаалдын амьдардаг газар байжээ (мэж 587). Иерусалимд буцан очиж, ариун сүмийг дахин барихыг иудейчүүдэд зөвшөөрсөн Кореш хааны үеийг хүртэл иудейчүүд Вавилоны боолчлолд 70 жил байжээ. Тэрчлэн Небухаднезар, Белшазар болон Дари I-ийн хаанчлалын дор бошиглогч Даниел энд амьдарч байв (Эхл. 10:10; 11:1-9; Хаалд.лэд 24-25; Иер. 27:1-29:10; Езек. 1:1; Дан. 1-12; Омнай 1:22; Ифр. 1:33-43).
4. **Шушан (Суза)** (Их Дари), Дари I, Херхез (Ахасуер)-ийн хаанчлалын үеийн Персийн эзэнт гүрний нийслэл. Эр зориг хийгээд итгэл нь иудейчүүдийг аварсан Хатан хаан Естерийн харш, Даниел, дараа нь Нехемиа энд үйлчилж байжээ (Нех. 1:4; 2:1; Ест. 1:1; Дан. 8:2).
5. **Дура Шадрахын Тал** Небухаднезарын бүтээсэн алтан дүрсийг шүгээх тагталдаар Мешах, Абд-него хоёр галт зууханд хаягджээ; тэднийг Бурханы Хүү аварсан бөгөөд тэд зуухнаас гэмтэлгүйгээр гарч ирсэн байна (Дан. 3).
6. **Ассири** Ассири нь Ниневийн дараа Ассирийн анхны нийслэл хот байв. мэж 721 онд Ассирийн хаад болох Шалманезер V болон Саргон II нар Израйлын Умард Хаант Улсыг эзэлж, 10 овгийг нь боолчлолд аваачжээ (Хаад. лэд 14-15, 17-19). Вавилон Ассирийг эзлэн авсан мээ 612 онг хүртэл Ассири нь Иудейг эзлэн түрэмгийлсэн ажээ.
7. **Ниневе** Ассирийн нийслэл. Хезекиагийн хаанчлал болон бошиглогч Исаиагийн тохиууллын үед Ассири Иудейн нутаг уруу довтложээ. Тэнгэр элч Ассирийн 185, 000 цэргийг гал цохисноор Иудейн нийслэл Иерусалим гайхамшигтайгаар аврагджээ (Хаад. лэд 19:32-37). Энэ хотод наманчлалыг тунхагла хэмээн Их Эзэн бошиглогч Ионад хэлсэн билээ (Иона 1:2; 3:1-4).
8. **Харан** Канаан уруу явахаасаа өмнө хэсэг хугацаанд Абрахам энд амьдарч байв. Абрахамын аав болон ач үлджээ. Ребека (Исаакийн эхнэр) болон Рахел, Леа, Вилха, Зилпа (Исаакийн эхнэрүүд) нар энэ нутгаас гаралтай (Эхл. 11:31-32; 24:10; 29:4-6; Абр. 2:4-5).
9. **Кархемш** Энд Фарао Нехо Небухаднезарт ялагданаар Канаанд Египетийн дарангуйлал төгсгөл болжээ (1Ист. лэд 35:20-36:6).
10. **Сидон** Энэ хотыг Хамын ач Сидон олсон бөгөөд энэ нь Канааны хамгийн хойд талын хот юм (Эхл. 10:15-20). Израилд Баалыг шүтэхийг нэвтрүүлсэн Иезебелийн нутаг байжээ (Хаад. лэд 16:30-33).
11. **Тир** Энэ нь Сирийн худалдааны чухал далайн боомт хот юм. Тирийн Хайрам Соломоны ариун ажлыг барихад нь нэмэрлэхээр хуш, алт болон амжилтын илгээлэг байв (Хаад. лэд 5:1-10, 18; 9:11).
12. **Дамаск** Абрахам Лотыг үүний ойролцоо аварчээ. Сирийн гол хот байв. Давид Хааны хаанчлалын үед нэрлэлчүүд хотыг булаан эзэлжээ. Елиа Хазаельг Дамаскийн хаан байхаар адисалсан ажээ (Эхл. 14:14-15; 2 Сам. 8:5-6; Хаад. лэд 19:15).
13. **Канаан** Абрахам болон түүний үр удамд энэ нутгийг үүрдийн эзэмшил болгон гэжээ (Эхл. 17:8).
14. **Синай уул (Хороб)** Их Эзэн Мосегтэй шатаж буй бутан дундаас ярьжээ (Ег. 3:1-2). Мосег хууль болон Арван Зарлиг өгөгдсөн юм (Ег. 19-20). Их Эзэн Елгагтэй намуун хүнгэнэх дуугаар ярьжээ (Хаад. лэд 19:8-12).
15. **Езрон-гебер** Езрон-геберт Соломон Хаан пэргийн хөлөг онгоцнуудыг барьжээ (Хаад. лэд 9:26). Далайн энэ боомтод Соломоны алдар хүндийг сонсохыхоо дараа хатан хаан Шеба түүнтэй уулзахаар иржээ (Хаад. лэд 10:1-13).
16. **Египет** Урд, их өлстөглөн болсны улмаас Абрахам энд хүрч иржээ (Абр. 2:1, 21). Өөрт нь заасан зүйлийг египетчүүдэд заа хэмээн Их Эзэн Абрахам хэлсэн аж (Абр. 3:15). Иосефын ах нар түүнийг боол болгон худалджээ (Эхл. 37:28). Иосеф энд Потифарын гэрийн захиргуч болов. Тэрээр шоронд хаягдсан байна. Тэрээр Фараогийн зүүдийг тайлсан учир, түүнд Египетэд эрх мэдлийг өгчээ. Иосеф ах нарын хаа хамт аврагджээ. Иаков болон түүний гэр бүл энд нүүж ирсэн байна (Эхл. 39-46). Израйлын хүүхдүүд Египетэд хэсэг хугацаанд байхдаа Гоптенд амьдарч байв (Ег. 12:31-41). Иеремиа Египетэд авчрагдав (Иер. 43:4-7). Израилчууд осөж уржин, "үлэмж хүчтэй болжээ"; дараа нь тэд египетчүүдийн боолчлолд орсон юм (Ег. 12:31-41). Иеремиа Египетэд авчрагджээ (Иер. 43:4-7).
17. **Кафрэт (Крет)** Миноанчуудын эртний нутаг.


1. **Дан (Лайш)** Умард Хаант Улсын шүтээний тулд Иеробоам алтан тугал бүтээжээ (Хаад. дээд 12:26–33). Дан нь эртний Израилын хамгийн хойд хязгаар байв.
2. **Кармел уул** Елиа Баалын санваартнуудыг сорьж, бороо оруулахын тулд тэнгэрийг нээжээ (Хаад. дээд 18:17–40).
3. **Мегиддо** Олон дайн болсон газар (Шүүгч. 4:13–16; 5:19; Шаст. дэд 35:20–23; Хаад. дэд 23:29). Мегиддог барихын тулд Соломон албадлагын ажилчдыг өсгөжээ (Хаад. дээд 9:15). Иудейн Хаан Иосиа Египетийн Фарао Некогийн эсрэг тулалдаанд шархалсан аж (Хаад. дэд 23:29–30). Их Эзэний Хоёр дахь Ирэлтээр агуу хийгээд сүүлчийн дайн Армагеддоны тулалдааны хэсэг Израелийн хөндийд болох болно (Иоел 3:4; Илч. 16:16; 19:11–21). Армагеддон гэдэг нэр нь еврей хэлний *Har Megiddon* буюу Мегиддо уул гэсэн үгийг грек үсгээр буулгасан хэлбэр юм.
4. **Изреел** Израилын хамгийн том бөгөөд үржил шимт хөндийтэй ижил нэртэй хотын нэр. Умард хаант улсын хаад энд ордон барьжээ (2 Сам. 2:8–9; Хаад. дээд 21:1–2). Ёс бус хатан хаан Иезебел энд амьдарч байв, мөн энд нас баржээ (Хаад. дээд 21; Хаад. дэд 9:30).
5. **Бет-шан** Израилчууд канаанчуудтай энд тулгарчээ (Иош. 17:12–16). Саулын биеийг энэ цайзын хананд хүлсэн ажээ (1 Сам. 31:10–13).
6. **Дотан** Ах нар нь Иосефыг боол болгон худалдав (Эхл. 37:17, 28; 45:4). Елиша морьд болон луусаар дүүрэн уулын тухай үзэгдлийг харжээ (Хаад. дэд 6:12–17).
7. **Самари** Умард Хаант Улсын нийслэл (Хаад. дээд 16:24–29). Ахаб хаан Баалд зориулан ариун сүм барьжээ (Хаад. дээд 16:32–33). Елиа Елиша нар тохинуулцгаажээ (Хаад. дээд 18:2; Хаад. дэд 6:19–20). мөө 721 онд ассирчууд үүнийг булаан эзэлж 10 овгийг бүрэн эзэлж дууссан байна (Хаад. дэд 18:9–10).
8. **Шехем** Абрахам тахилын ширээ босгожээ (Эхл. 12:6–7). Иаков үүний хажууд амьдарч байв. Симеон, Леви хоёр энэ хотын бүх эрчүүдийг устгажээ (Эхл. 34:25). “Энэ өдөр Бурханд үйлчлэхээр сонго” хэмээх Иошуагийн зоригжуулалт Шехемд иржээ (Иош. 24:15). Энд Иеробоам Умард Хаант Улсын анхны нийслэлийг үүсгэн байгуулжээ (Хаад. дээд 12).
9. **Ебал уул болон Геризим уул** Иошуа энэ уулан дээрээс Израилыг хоёр хуваажээ—зүхлүүд Ебал уулнаас гарч ирэх үед хуулийн адислалууд Геризим уулнаас тунхаглагджээ (Иош. 8:33). Самаричууд хожим нь Геризим дээр ариун сүм босгосон ажээ (Хаад. дэд 17:32–33).
10. **Пенуел (Пениел)** Энд Иаков Их Эзэний элчтэй шөнөжингөө өөртэйгөө тэмцэлдэн ярилцжээ (Эхл. 32:24–32). Мидианы цайзыг Гидеон устгажээ (Шүүгч. 8:5, 8–9).
11. **Иоппа** Иона Ниневед хийх номлолоосоо зугтан эндээс Таршиш уруу явжээ (Иона 1:1–3).
12. **Шило** Шүүгчдийн үед Израилын нийслэл болон асар энд байдаг байв (1 Сам. 4:3–4).
13. **Бетел (Луз)** Энд Абрахам Лотоос салан явсан (Эхл. 13:1–11) бөгөөд үзэгдэл харжээ (Эхл. 13; Абр. 2:19–20). Шат тэнгэрт хүрч байгаа үзэгдлийг Иаков харсан аж (Эхл. 28:10–22). Хэсэг хугацаанд асар энд байрлаж байв (Шүүгч. 20:26–28). Иеробоам Умард Хаант Улсын шүтлэгт зориулж алтан тугал бүтээжээ (Хаад. дээд 12:26–33).
14. **Гибен** Хиви хүмүүс энд Иошуаг мэхэлжээ (Иош. 9). Иошуаг тулалдаанд ялтал нар гарсаар байв (Иош. 10:2–13). Энэ нь тэрчлэн түр хугацаанд асрын газар байжээ (Шаст. дээд 16:39).
15. **Газ, Ашдод, Ашкелон, Экрон, Гат (Филистийн таван хот)** Эдгээр хотуудаас филистинчүүд израилчуудтай дайн хийдэг байв.
16. **Бетлехем** Рахелыг үүний ойролцоо оршуулжээ (Эхл. 35:19). Рут, Боаз хоёр энд амьдарч байв (Рут 1:1–2; 2:1, 4). Үүнийг Давидын хот хэмээн нэрлэдэг байв (Лук 2:4).
17. **Хеброн** Абрахам (Эхл. 13:18), Исаак, Иаков (Эхл. 35:27), Давид (2 Сам. 2:1–4), Абсалом нар (2 Сам. 15:10) энд амьдарч байв. Давид Хааны удирдлага дор энэ нь Иудейн нийслэл байжээ (2 Сам. 2:11). Абрахам, Сара, Исаак, Ребека, Иаков, Леа нар энд Макпелагийн агуйд оршуулагдсан гэдэгт хүмүүс итгэдэг (Эхл. 23:17–20; 49:31, 33).
18. **Ен-геди** Давид Саулаас нуугдаж, мөн Саулын амийг өршөөжээ (1 Сам. 23:29; 24:1–22).
19. **Герар** Хэсэг хугацаанд Абрахам Исаак хоёр энд амьдарч байв (Эхл. 20–22; 26).
20. **Бершеба** Энд Абрахам худаг ухаж мөн Абимелехтэй гэрээ байгуулжээ (Эхл. 21:31). Исаак Их Эзэнийг харж (Эхл. 26:17, 23–24) мөн Иаков энд амьдарч байв (Эхл. 35:10; 46:1).
21. **Содом ба Гоморра** Лот Содомд амьдрахаар шийдсэн байв (Эхл. 13:11–12; 14:12). Ёс бусынх нь улмаас Содом Гоморра хоёрыг Бурхан устгажээ (Эхл. 19:24–26). Хожим нь эдгээр хотуудыг Есүс ёс бусын бэлгэдэл болгон хэрэглэсэн байдаг (Мат. 10:15).



1. **Тир ба Сидон** Есүс Коразин болон Бетсайдыг Тир болон Сидонтой харьцуулдаг байв (Мат. 11:20–22). Тэрээр харь эмэгтэйн охиныг эдгээжээ (Мат. 15:21–28).
2. **Хувиралтын уул** Есүс Петр, Иаков, Иоханы өмнө хувирч мөн тэд хаант улсын түлхүүрүүдийг хүлээн авчээ (Мат. 17:1–13). (Зарим хүмүүс Хувиралтын уулыг Хермон уул гэдэгт итгэдэг; зарим хүмүүс үүнийг Табор уул гэдэгт итгэдэг.)
3. **Цезарь Филип** Есүс бол Христ хэмээн Петр гэрчилсэн бөгөөд түүнд хаант улсын түлхүүрүүд амлагджээ (Мат. 16:13–20). Есүс өөрийнхөө үхэл болон амилалтыг утган хэлжээ (Мат. 16:21–28).
4. **Галилын муж** Есүс амьдралынхаа болон тохинууллынхаа ихэнхийг Галилд өнгөрүүлсэн юм (Мат. 4:23–25). Энд тэрээр Уулан дээрх номлолыг өгчээ (Мат. 5–7); уяман өвчтэй хүнийг эдгээв (Мат. 8:1–4); мөн зөвхөн Искарриотын Иудас л Галилын бус байсан Арванхоёр Төлөөлөгчийг сонгож, томилж мөн урагш илгээжээ (Марк 3:13–19). Амилсан Христ Галилд Төлөөлөгчид дээр хүрч иржээ (Мат. 28:16–20).
5. **Галилын тэнгис, хожим нь Тиберийн тэнгис хэмээн нэрлэгджээ** Есүс Петрийн завин дээрээс заасан бөгөөд Петр, Андрей, Иаков, Иохан нарыг хүмүүний загасчид байхаар дууджээ (Мат. 4:18–22; Лук 5:1–11). Тэрчлэн тэрээр тэнгисийн шуургыг намдааж (Лук 8:22–25), завин дээрээс сургаалт зүйрлэлүүдийг зааж (Мат. 13), тэнгис дээгүүр алхаж (Мат. 14:22–32), мөн Амилсныхаа дараа шавь нартаа үзэгджээ (Иохан 21).
6. **Бетсайд** Петр, Андрей, Филип нар Бетсайдад төржээ (Иохан 1:44). Бетсайдын ойролцоо Төлөөлөгчдийн хамт Есүс явж байв. Хурсан олон түүнийг дагаж, тэрээр 5000 хүнийг хооллов (Лук 9:10–17; Иохан 6:1–14). Энд Есүс хараагүй хүнийг эдгээжээ (Марк 8:22–26).
7. **Капернаум** Энд Петр амьдарч байв (Мат. 8:5, 14). Есүсийн өөрийн хот хэмээн Матайн нэрлэсэн Капернаумд Есүс саа өвчтэй хүнийг эдгээж (Мат. 9:1–7; Марк 2:1–2), зуутын даргын зарцыг анагаан, Петрийн эхнэрийн ээжийг эдгээж (Мат. 8:5–15), Матайг Төлөөлөгчдийнхөө нэг байхаар дуудан (Мат. 9:9), хараагүй хүний нүдийг нээж, чөтгөрийг зайлуулж (Мат. 9:27–33), Хүндэтгэлийн өдөр хүний хатингар гарыг эдгээж (Мат. 12:9–13), амьдралын талхны тухай зааж (Иохан 6:22–65), мөн татвар төлөхийг зөвшөөрч, бас загасны амнаас мөнгө авахыг Петрт хэлжээ (Мат. 17:24–27).
8. **Магдал** Энд Магдалын Мариа амьдардаг байв (Марк 16:9). 4000 хүнийг хооллоосныхоо дараа Есүс энд ирсэн (Мат. 15:32–39) бөгөөд тэнгэрээс тэмдэг үзүүлэхийг түүнээс фарисайчууд болон садукайчууд хүссэн ажээ (Мат. 16:1–4).
9. **Кана** Есүс усыг дарс болгосон (Иохан 2:1–11) бөгөөд Капарнаумд байсан хааны түшмэлийн хүүг эдгээжээ (Иохан 4:46–54). Кана бол бас Натаны амьдарч байсан газар юм (Иохан 21:2).
10. **Назар** Назарт Мариа Иосеф хоёрт тэнгэр элчийн захиас иржээ (Мат. 1:18–25; Лук 1:26–38; 2:4–5). Египетээс буцаж ирсний дараа Есүс хүүхэд насаа энд өнгөрөөж (Мат. 2:19–23; Лук 2:51–52), тэрээр Мессиа гэдгээ зарлаж, мөн өөрсдийнхнөөрөө эсэргүүцэгджээ (Лук 4:14–32).
11. **Иерихо** Есүс хараагүй хүнийг хараатай болгов (Лук 18:35–43). Тэрчлэн тэрээр татвар хураагчдын ахлагч Закхайтай хамт хоолложээ (Лук 19:1–10).
12. **Ветафа** Цөлд хашгирах дуу хоолой хэмээн Иохан Баптист өөрийгөө гэрчилжээ (Иохан 1:19–28). Иордан голд Иохан Есүст баптисм хүртгээж, Есүс бол Бурханы Хурга хэмээн гэрчилжээ (Иохан 1:28–34).
13. **Иудейн цөл** Энэ цөлд Иохан Баптист номложээ (Мат. 3:1–4), мөн энд Есүс 40 хоног мацаг бариж, соригдсон байна (Мат. 4:1–11).
14. **Еммау** Амилсан Христ хоёр шавийнхаа хамт Еммау хүрэх замаар явж байв (Лук 24:13–32).
15. **Бетфа** Хоёр шавь нь Есүст дудран авчирч, тэрээр Иерусалимд ялгуусан байдлаар оржээ (Мат. 21:1–11).
16. **Бетан** Мариа, Марта, Лазар нар энд амьдардаг байв (Иохан 11:1). Марта Есүсийн үгсийг сонсож, сайн зүйлийг сонгосон тухай Есүс Мартад хэлжээ (Лук 10:38–42); Есүс Лазарыг нас барагсдаас босгожээ (Иохан 11:1–44); мөн Мариа Есүсийн хөлийг тослов (Мат. 26:6–13; Иохан 12:1–8).
17. **Бетлехем** Есүс төрж, түүнийг тэжээлийн төвшинд тавьжээ (Лук 2:1–7); Есүсийн төрснийг хоньчдод тэнгэр элчүүд зарлажээ (Лук 2:8–20); Одод мэргэн хүмүүсийг Есүс уруу хөтөлжээ (Мат. 2:1–12); мөн Херод хүүхдүүдийг цаазалсан ажээ (Мат. 2:16–18).

1. **Голгота** Есүсийн цовдлогдсон байж магадгүй газар (Мат. 27:33–37).
2. **Булшны цэцэрлэг** Есүсийг оршуулжээ (Иохан 19:38–42). Амиласн Христ Магдалын Мариад цэцэрлэгт үзэгджээ (Иохан 20:1–17).
3. **Антионы цайз** Энэ газар Есүс буруушаагдаж, яллагдаж, шоглуулж, мөн цээрлүүлэгдсэн байж болох юм (Иохан 18:28–19:16). Паул баригдаж мөн хөрвөлтийнхөө түүхийг ярьжээ (Үйлс 21:31–22:21).
4. **Бетеслагийн цөөрөм** Хүндэтгэлийн өдөр Есүс тахир дутуу хүнийг эдгээжээ (Иохан 5:2–9).
5. **Ариун сүм** Хүүхэдтэй болно хэмээн Захариа, Елизабет хоёрт Габриел амлажээ (Лук 1:5–25). Аврагчийг нас барахад ариун сүмийн хөшиг цуурчээ (Мат. 27:51).
6. **Соломоны жигүүрийн асар** Есүс Бурханы Хүү гэдэгт тунхаглажээ. Иудейчүүд түүнийг чулуугаар шидэхийг оролдов (Иохан 10:22–39). Хазгар хүнийг эдгээснийхээ дараа Петр наманчлалыг номложээ (Үйлс 3:11–26).
7. **Үзэсгэлэнт хаалга** Хазгар хүнийг Петр, Иохан хоёр эдгээжээ (Үйлс 3:1–10).
8. **Ариун сүмийн орой** Сатан Есүсийг сорьсон байна (Мат. 4:5–7). (Ам дамжсан яриагаар, энэ үйл явдал болсон гэх хоёр газар байдаг.)
9. **Ариун уул** (Тодорхой бус газрууд)
 - а. Ам дамжсан яриагаар, энд Абрахам Исаакийг тахилд өргөхийн тулд тахилын ширээ босгожээ (Эхл. 22:9–14).
 - б. Соломон Ариун сүм барьжээ (Хаад. дээд 6:1–10; Шаст. дэд 3:1).
 - в. Ойролцоогоор мэ 587 онд вавилончууд ариун сүмийг устгажээ (Хаад. дэд 25:8–9).
 - г. Ойролцоогоор мэ 515 онд Зеруббабел ариун сүмийг дахин барьжээ (Езра 3:8–10; 5:2; 6:14–16).
 - д. Херод ариун сүмийн талбайг томсгож мөн мэ 17 онд ариун сүмийг дахин барьжээ. Есүс хүүхэд байхдаа энд иржээ (Лук 2:22–39).
 - е. 12 настайдаа Есүс ариун сүмд заав (Лук 2:41–50).
 - ё. Есүс ариун сүмийг цэвэршүүлжээ (Мат. 21:12–16; Иохан 2:13–17).
 - ж. Хэд хэдэн тохиолдолд Есүс ариун сүмд заажээ (Мат. 21:23–23:39; Иохан 7:14–8:59).
 - з. Титийн удирдсан ромчууд ариун сүмийг мэ 70 онд устгажээ.
10. **Гетсеманийн цэцэрлэг** Есүс зовж, түүнээс урваж, мөн баригджээ (Мат. 26:36–46; Лук 22:39–54).
11. **Чидуны уул**
 - а. Иерусалим болон ариун сүмийн сүйрлийг Есүс угтан хэлжээ. Тэрээр Хоёр дахь Ирэлтийн тухай ярьжээ (Мат. 24:3–25:46; ИС—М-г мөн үз).
- б. Эндээс Есүс тэнгэрт дээшлэн одсон аж (Үйлс 1:9–12).
- в. 1841 оны аравдугаар сарын 24-нд Абрахамын хүүхдүүд буцаж ирэхийн төлөө Ариун нутгийг Ахлагч Оорсон Хайд онцгойлон адисалжээ.
12. **Гихон булаг** Соломоны хаан байхаар адисалжээ (Хаад. дээд 1:38–39). Хезекиа суваг ухах, хот уруу ус оруулж иржээ (Шаст. дэд 32:30).
13. **Усны хаалга** Езра Мосегийн Хуулийг хүмүүст уншиж мөн тайлбарлаж өгчээ (Нех. 8:1–8).
14. **Хиннон хөндий** Хүүхдийг тахилд өргөхийг багтаадаг байсан хуурамч бурхан Мохыг энд шүтдэг байв (Хаад. дэд 23:10; Шаст. дэд 28:3).
15. **Каиафын гэр** Есүсийг Каиафын өмнө авчирчээ (Мат. 26:57–68). Есүсийг таньдага Петр үгүйсгэв (Мат. 26:69–75).
16. **Дээд өрөө** Есүс Дээгүүр өнгөрөх баярын зоогийг идэж, ариун ёслолыг нэвтрүүлсэн уламжлалт газар (Мат. 26:20–30). Тэрээр Арванхоёрын хөлийг угааж, (Иохан 13:4–17) тэдэнд заажээ (Иохан 13:18–17:26).
17. **Херодын ордон** Энэ газар Христийг Херодын өмнө авч ирсэн байж болох юм (Лук 23:7–11).
18. **Иерусалим** (Тодорхой бус газрууд)
 - а. Мелкизедек Салемыг захирч байв (Эхл. 14:18).
 - б. Давид Хаан хотыг иебусчуудаас булаан авчээ (2 Сам. 5:7; Шаст. дээд 11:4–7).
 - в. мэ 587 онд вавилончууд хотыг устгажээ (Хаад. дэд 25:1–11).
 - г. Пентекостын өдөр олон хүмүүс Ариун Сүнсээр дүүрсэн байв (Үйлс 2:1–4).
 - д. Петр Иохан хоёр баригдаж, зөвлөлийн өмнө авчрагдав (Үйлс 4:1–23).
 - е. Ананиа Сапфир хоёр Их Эзэнд худал хэлэн нас барав (Үйлс 5:1–10).
 - ё. Петр Иохан хоёр баригдав, гэвч тэнгэр элч тэднийг шоронгоос суллажээ (Үйлс 5:17–20).
 - ж. Төлөөлөгчид долоон эрэгтэйг өөрсдөдөө туслуулахаар сонгов (Үйлс 6:1–6).
 - з. Стефаны гэрчлэлийг иудейчүүд эсэргүүцэв, мөн тэрээр чулуугаар шидүүлэн нас барав (Үйлс 6:8–7:60).
 - л. Иаков алагдав (Үйлс 12:1–2).
 - м. Тэнгэр элч Петрийг шоронгоос чөлөөлөв (Үйлс 12:5–11).
 - н. Төлөөлөгчид хөвч хөндөх ёслолын талаар шийдвэр гаргав (Үйлс 15:5–29).
 - о. мэ 70 онд Титийн удирдсан ромчууд хотыг устгажээ.







20. **Филиппий** Паул, Сила, мөн Тимот нар Лукия хэмээх эмэгтэй хөрвүүлж, муу ерын сүнснийг зайлуулж мөн жанчуулжээ (Үйлс 16:11–23). Тэд шоронгоос зугтах тэнгэрлэг тусламжийг олж авчээ (Үйлс 16:23–26).
21. **Афин** Паул хоёр дахь номлолоороо Афинд байх үед Марс Хилд (Ареопа) үл мэдэгдэх бурхдын тухай номлон (Үйлс 17:22–34).
22. **Коринт** Паул хоёр дахь номлолоороо Коринт уруу явж, тэнд Акул Приксила нартай хамт байжээ. Тэрээр энд номлож мөн олон хүмүүст багтисм хүртээжээ (Үйлс 18:1–18). Коринтоос Паул ромчуудад захидал бичсэн ажээ.
23. **Тессалони** Хоёр дахь номлолоор явж байхдаа Паул энд номложээ. Иудейчүд аюулгүй байдалд нь халдсаны дараа түүний номлогчийн бүлэг Берой уруу явчгаажээ (Үйлс 17:1–10).
24. **Берой** Паул, Сила, мөн Тимот нар Паулын хоёр дахь номлолын үеэр уужуу сэтгэлтэй хүмүүстэй тааралджээ. Тессалоникийн иудейчүд тэднийг дагаж мөн мөрдөн хавчжээ (Үйлс 17:10–13).
25. **Македони** Хоёрдахь болон гурав дахь аяллаараа Паул энд номложээ (Үйлс 16:9–40; 19:21). Түүнд болон Иерусалим дахь ядуу Гэгээнтнүүдэд өгсөн Македонийн Гэгээнтнүүдийн өгөөмөр сэтгэлийг Паул магтээж (Ром 15:26; 2 Кор. 8:1–5; 11:9).
26. **Малг** Паул Ром уруу явах замдаа энэ арал дээр усан онгоцны сүйрэлд орсон байна (Үйлс 26:32; 27:1, 41–44). Тэрээр хорт могойг хатуулан хорлоогүй бөгөөд Малгтад байсан олон өвчтэй хүмүүсийг элгээжээ (Үйлс 28:1–9).
27. **Ром** Хоёр жил гэрийн хорьцол байхдаа Паул энд номложээ (Үйлс 28:16–31). Тэрчлэн тэрээр Ромд хоригдож байхдаа ефесчүд, филиппчүд, колосайчүд болон Тимот, Филемон нарт захиглууд бичиж байв. мэ 64 оноос Неро Христийнний мөрдөн хавчигч эхэлснээс хойш улаагүй байх үед Петр анхны захидала Вавилон хэмээн нэрлэгдсэн Гомоос бичсэн байж болох юм. Петр Паул хоёр энд алагдсан гэдэгт ихэнх хүмүүс итгэлдэг.

1. **Газ** Филипп Христийн тухай номлож, Газ хүрэх замдаа Эголийн тайган амбанд багтисм хүртээжээ (Үйлс 8:26–39).
2. **Иерусалим** Иерусалимд болсон үйл явдлуудыг газрын зураг 12-оос үз.
3. **Иопта** Наманчлалын бэлгийг Бурхан харийканд өгсөн үзэгдлийг Петр харжээ (Үйлс 10; 11:5–18). Петр Табагта нас барагсаас амилуулжээ (Үйлс 9:36–42).
4. **Самари** Филип Самарид тохинуулжээ (Үйлс 8:5–13), мөн Петр Иохан хоёр хожим нь энд зааж байв (Үйлс 8:14–25). Тэд Ариун Сүнсний өгсний дараа төлөгч Симон энэ бэлгийг тэднээс худалдан авахыг хичээв (Үйлс 8:9–24).
5. **Цезарь** Энд, зуутын дарга Корнелл тэнгэр элч тохионуулсны дараа түүнийг багтисм хүртэхийг Петр зөвшөөрчээ (Үйлс 10). Энд Паул Аргийн өмнө өөрийгөө хамгаалжээ (Үйлс 25–26; тэрчлэн ИС—1:1, 24–25).
6. **Дамаск** Есүс Саулд үзэгджээ (Үйлс 9:1–7). Ананиа Саулыг хараатай болгов, Саул багтисм хүртэж мөн тохионуулаа эхэлжээ (Үйлс 9:10–27).
7. **Антиох (Сири дэх)** Энд шавь нарыг анх удаа Христийнхэн хэмээн дууджээ (Үйлс 11:26). Агабу елстөлөнгийн тухай бошиглов (Үйлс 11:27–28). Антиоход хөвч хөндөх тухайд их зөрчилдөөн гарчээ (Үйлс 14:26–28; 15:1–9). Антихоход Паул хоёр дахь номлолоо Силас, Барнаб, мөн Иудейн Барсаб нарын хамт эхэлжээ (Үйлс 15:22, 30, 35).
8. **Тарс** Паулын төрөлх хот; Ах нар Паулын амийг аврахын тулд түүнийг тийш нь явуулжээ (Үйлс 9:29–30).
9. **Кипр** Хавчигдад эхэлсний дараа зарим Гэгээнтнүүд энэ арал дээр зугтаж иржээ (Үйлс 11:19). Паул анхныха номлолын аяллаар, хожим нь Барнаб, Марк хоёр дайран өнгөрөнций адилаар (Үйлс 15:39) Киприйг дайран өнгөрчээ (Үйлс 13:4–5).
10. **Паф** Паул шилтэнг хараажээ (Үйлс 13:6–11).
11. **Дерб** Энэ хотод Паул Барнаб хоёр сайн мэдээг номлон (Үйлс 14:6–7, 20–21).
12. **Лустр** Паул дутуур дутуур хүнийг элгээхэд Барнаб тэр хоёр бурхан мэт шүтэглэжээ. Паул чулуугаар ш-

- дүүлж, мөн Лустрин хүмүүс түүнийг үхсэн хэмээн бодсон боловч, сэргээх номлолоо үргэлжлүүлжээ (Үйлс 14:6–21). Тимотын тэр (Үйлс 16:1–3).
13. **Иконинум** Паул Барнаб хоёр анхныха номлолоор энд номлосон бөгөөд чулуугаар шидүүлжээ (Үйлс 13:51–14:7).
14. **Лоддик ба Колос** Лоддик нь Паулын очсон болон захидал хүлээн авсан Сүмийн салбаруудын нэг (Кол. 4:16). Тэрчлэн Илчлэлтийн номонд бичигдсэн лоддион хотын нэг (бусад нь Ефес, Смирна, Пергам, Туатейр, Сардий, ба Филалельфий; Илч. 1:11–1 үз). Колос нь Лоддикээс зүүн тийш 18 километрт оршдог. Паул энд амьдарч байсан Гэгээнтнүүдэд захидал бичжээ.
15. **Антиох (Писидиа дахь)** Христ нь Давидын удмаас ирсэн үзэгдлийг Паул Барнаб хоёр анхныха номлолоор илэрхийлжээ (Үйлс 13:46). Паул сайн мэдлэг нь раллиуудад, дараа нь харийканд түгээжээ. Паул Барнаб хоёр хавчигдаж мөн хөөгдсөн ажээ (Үйлс 13:51–50).
16. **Милет** Гурав дахь номлолынхоо үеэр энд байхдаа сүрэгт орж ирж болзошгүй дотшин чононуудаас сэргэмжэхийг Паул Сүмийн ахлагч нарт сануулжээ (Үйлс 20:29–31).
17. **Патм** Одоо Илчлэлтийн номонд агуулагддаг үзэгдлийг хүлээн авах үедлээ Иохан энэ арал дээр хоригдож байв (Илч. 1:9).
18. **Ефес** Англоо энд сүр хүчээр номложээ (Үйлс 18:24–28). Паул гурав дахь номлолоороо Ефес хоёр жил номлож, олон хүмүүсийг хөрвүүлжээ (Үйлс 19:10, 18). Энд тэрээр гар тавилтаар Ариун Сүнсний бэлгийг хүртээж (Үйлс 19:1–7) мөн муу ерын сүнснийг зайлуулах зэрэг олон гайхамшгуудыг үйлдэж (Үйлс 19:8–21). Энд Дианаг шүтэгчид Паулын эсрэг самуун дэглэжээ (Үйлс 19:22–41). Илчлэлтийн номонд нэг хэсэг нь Ефес байсан Сүмийнхэнд зориулагдсан аж (Илч. 1:11).
19. **Трой** Хоёр дахь номлолоор энд байхдаа Паул Македонд нэгэн хүн тусламж хуви буй үзэгдлийг харжээ (Үйлс 16:9–12). Энд гурав дахь номлолоор явж байхдаа Паул Ютухыг нас барагтсаас босгов (Үйлс 20:6–12).



*Өндөрлөгүүдийн ялгааг илүү тодорхой харуулахын тулд *хотгор гүдгэрийн байрзүйн зургийг томруулсан болно*



1. Нил мөрөн ба Египет Үүнтэй төстэй газар Мосегийн эх нялх хүүхдээ нуужээ. Фараогийн охин түүнийг олж Египетийн хааны ордонд өсгөсөн байна.



2. Синай уул (Хорев) ба Синайн цөл Зарлигийн дагуу Мосе израилчуудад зориулсан Бурханы хуулийг энэ уулан дээр хүлээн авчээ. Энэ гэрэл зураг Синай уулын ам дамжин яригддаг газрыг харуулжээ.



3. Иудейн цөл ба Сөнөсөн тэнгис Аврагч цөлд ирж Эцэгтэйгээ ярилцжээ.



4. Кадеш-барне Кадеш барне хэмээн нэрлэгддэг энэ газар нь израилчууд 40 жил цөлд аялсныхаа ихэнх үед буудаллаж байсан нутаг юм.



5. Патриархуудын бунхнууд Хебронд байдаг энэ барилга Абрахам, Исаак, Иаков нарын булшин дээр баригдсан хэмээн яригддаг.



6. Иудейн уулархаг нутаг Иерусалимын урд болон зүүн хэсэг хүртэлх Ариун нутгийн ихэнх хэсгийг эзэлдэг уулархаг нутаг.



7. БЕТЛЕХЕМ Энэ хотод Их Эзэн Есүс Христ төржээ.



8. ИЕРУСАЛИМ Энэ хот—Христийн, Иудейн хийгээд Лалын гэсэн гурван шашны ариун хот хэмээн тооцогддог.



9. Херодын Ариун Сүм Энэ загвар нь эртний ариун сүмийн нарийн хэмжээг яг дууриалган хийсэн хэмээн тооцогддог.



10. Ариун Сүмийн довжоо Херодын Ариун Сүм уруу хөтөлсөн энэ довжоог археологчид олсон ажээ.



11. Чидуны уул, Оорсон Хайдын цэцэрлэг 1841 онд үүний ойролцоо Ахлагч Оорсон Хайд Абрахамын хүүхдүүдийг буцаж ирэхийн төлөө Ариун нутгийг онцгойлон адисалжээ.



12. Гетсеманийн Цэцэрлэг Тэрээр цагаатгалаа эхлэх үед Аврагчийн залбирч мөн гашуун цусан дуслаа энэ цэцэрлэгт унагаж байсан моднуудын үндэснээс эртний чидуны модод ургасан байж болох юм.



13. Голгота Энэ газрын ойролцоо Их Эзэн Есүс Христ цовдлогдсон хэмээн олны дунд ам дамжин тархсан яриа байдаг.



14. Булшны цэцэрлэг Орчин үеийн хэд хэдэн бошиглогч Цовдлолтын дараа Аврагчийн цогцсыг Ариматын Иосефын булшны газар оршуулсан хэмээн үздэг.



15. ИЕРИХО Энэ нь Иошуагийн эзэлсэн эхний хот байв (Иош. 6:2–20-ийг үз); Иерихо бол дэлхий дээрх хамгийн эртний хотуудын нэг юм.



16. ШИЛО Гэрээний авдрыг агуулсан асар энэ газар байрлуулагдсан бөгөөд энд зуун зууны турш байсан билээ.



17. ГЕРИЗИМ УУЛ БА ЕБАЛ УУЛ Энэ хоёр уул Иосефын ясыг оршуулсан эртний хот Шехемын дээгүүр сүндэрлэн харагддаг (Иош. 24:32-ыг үз).



18. САМАРИЙН ДОТАН Энэ үржил шимт хөндийд Иосефын ах нар дүүгээ мирианчууд болон Ишмаелын худалдаачдад зарах үедээ сүргээ хариулж явжээ.



19. Кайсари ба Кармелын зам дахь Шароны тал Энэ хотод Паул Агрипп хаанд номложээ (Үйлс 26-г үз).



20. Иоппа Харийнханд сайн мэдээг хүргэхийг зааварчилсан үзэгдлийг Петр энд хүлээн авчээ (Үйлс 10-ыг үз).



21. ИЕЗРЕЕЛИЙН ХӨНДИЙ Армагеддоны тулалдаанд бүх үндэстэнүүд энд цугларах болно (Зех. 11–14, Илч. 16:14–21).



22. ТАБОР УУЛ Энэхүү алдартай газрын орой бол Христ өөрийн Төлөөлөгч Петр, Иаков, Иохан нарын өмнө хувирсан Хувиралтын газар мөн хэмээн ам дамжин тархжээ (Мат. 17:1–9-ийг үз).



23. Галилын тэнгис болон Ерөөлийн уул Энэхүү өндөр толгой нь Аврагчийн Уулан дээрх Номлолоо өгсөн газар хэмээн ам дамжсан яриа байдаг (Мат. 5-7-г үз).



24. КАПЕРНАУМ Аврагч өөрийн олон гайхамшгуудыг үйлдсэн хотыг харуулах зөвхөн хэдхэн балгас үлджээ.



25. Иордан гол Энэ голын гэрэл зургийг Галилын тэнгисийн цутгалан дээрээс авчээ.



26. Цезарь Филип Энэ газрын ойролцоо Есүс Христ хаант улсын түлхүүрүүдийг Петрт амласан байж болох юм.



27. Назар Энэ хотод Есүс насанд хүртлээ амьдарчээ.



28. Дан Израилын хамгийн хойд талын хил хэмээн нэгэнтээ тэмдэглэгдсэн Хуучин Гэрээний үеийн хот.



29. Афин Үл мэдэгдэх бурхдын талаар Паул номлосон Парфеноны ойролцоох Марсын Уулыг энд харуулжээ (Үйлс 17:15–34).



30. Коринт Энэ хотоос Паул ромчуудад захидлаа бичжээ.



31. Ефес Энд Паул хиймэл бурхан шүтэхийн эсрэг номлож, охин тэнгэр Дианагийн дүрсийг худалдан амьдардаг мөнгөний дархчуудыг уурлуулжээ (Үйлс 19:24–41).



32. Патмын арал Энэ бүх газар нутаг бол Илчлэгч Иоханы цөлөгдсөн Газрын Дундад Тэнгис дэх арлуудын нэг хэсэг юм.

MONGOLIAN



4 02344 04363 5

34404 363

MONGOLIAN



4 02347 44363 0

34744 363